

Ж.Р.Р.ТОЛКЕЙН



БӨГЖНИЙ
ЭЗЭН

Ж.Р.Р.Толкейн

БӨГЖНИЙ ЭЗЭН

Гурван бөгжийг асар тэнгэрт суугч хаанлаг эльфүүдэд,

Долоон бөгжийг чулуун тэрэмд суугч гномуудын эздэд,

Есөн бөгжийг булины хумхийн тоос өмсөгч Естүүдэд,

Нэг бөгжийг Мордор нэрт харанхуйн орноо

Хар ширээнээ залрагч Эзэн зүүх болой.

Нэг бөгж Мордор нэрт харанхуйн орноо

Тэднийг захирна, тэднийг хураана,

Нэг бөгж тэднийг хар гинжинд хэлхэж давтана

Өмнөх адал явдлын хураангуй

Хоббитуудын тухай

Бидний яриа ерөөсөө хоббитуудын тухай байх болно. Сониуч уншигч тэдний зан аашийн талаар их зүйл мэдэж авах боловч харин үүх түүхээс нь жаал жуул юм л дуулна. Хорхой нь хүрч хамгийн их сонирхоод байгаа хүмүүст “Хоббит” гэдэг нэртэй туужийг уншаарай гэе. Их ертөнц дэх бага ард түмнээ анх удаа алдаршуулсан Бильбо Торинсын туурвисан Баруун хязгаарын улаан номын эхний бүлгүүдэд өгүүлсэн байгаа. Эдгээр бүлэг “Тийшээ ба буцах замд” гэсэн ерөнхий нэртэй. Бильбо дорно зүг яваад эргэж ирсэн тухайгаа өгүүлсэн болохоор ийм нэр өгчээ. Хоббитууд гагцхүү Бильбогийн ачаар одоохон бидний танилцаж мэдэх гэж байгаа адал сонин хэрэг явдалд орооцолдсон юм. Гэхдээ ер нь Хоббитуудын талаар юу ч мэдэхгүй улс олон бий, тэгтэл мэдье гээд ч хэн хүний гарын доор “Хоббит” гэдэг ном байхгүй юм чинь. Хэрвээ олдож гэмээж нь Хоббитуудын тухай эхний мэдээллүүдийг уншаарай. Бас дашрамд нь Бильбод тохиолдсон жигтэй явдлуудыг уншина биз.

Хоббитууд бол нэг их сонин содон биш боловч маш эртний улс. Дээр үед одоогийнхоос хавьгүй олон байсан. Эднүүс чимээ шуугиангүй, амгалан тайван байх дуртай. Үржил шимт хөрстэй, өнгийн цэцэг алагласан нугад бас дуртай. Гэтэл эдүгээ дэлхий ертөнц даанч дэндүү чимээ шуугиантай агаад уйтан давчуу болжээ. Уран гартай, авхаалж самбаатай хоббитууд одоо дархны хөөрөг, усан тээрэм, ээрүүлээс арай нарийн багаж хэрэгслийг тэвчиж чадахаа байсан бөгөөд одоо ч тэвчихгүй байна.

Хоббитууд хүнээс бүр хэзээний дөлж цэрвэдэг байсан. Эдний хэлээр хүнийг Аваргас гэнэ. Одоо тэд хүний нүдэнд үзэгдэхээ ч байсан. Чих гэж атаархмаар сонор, нүд гайхалтай хурц. Хоббитууд жаахан бандгардуухан, тэгээд ч тэр үү, нэг их яарч тэвдэхгүй. Гэхдээ яарч сандрах юм гарвал хэний ч хойно орохгүй. Хоббитууд урилгагүй Аваргуудын барааг нэг л харвал нүд ирмэхийн зуур навчис хийсэхийн төдий ч чимээ гаргалгүй арилаад өгнө, бүр ингээд сурчихсан юм. Хүнд энэ нь ид шидтэн юмуу даа гэж бодогддог. Ийм л авхаалжтай амьтад даа. Гэтэл тэдэнд ямар юмных нь ид шид байх билээ дээ, ерөөсөө л байгалиас заяасан төрөлхийн ийм нуугдах авьяастай амьтад. Эднийг агшин зуурт нүднээс далд орохыг хүдэр бадир биет хөршүүд нь хараад гайхаж хоцорно. Хоббитууд жаахан шүү дээ. Хүний бүсэлхийгээр нь татмаар, тэр байтугай анахайгаас жижигхэн ч бий. Одоо гурван тохой хоббит ховорхон томдоо орно. Дээр үед ийм ч газрын бэтэг шиг байгаагүй гэлцэх. “Аранзал” номд өгүүлснээр бол хоёрдугаар Изенгримийн хүү Бандобрас Крол (Быкобор) дөрвөн тохой, таван ямх байсан юм гэдэг.

Хоббитуудын бүхий л түүхэнд үүнтэй зэрэгцэх мартагдашгүй хоёр байсан гэдэг. Энэ хоёрын тухай манай он цагийн дарааллын бичигт байдаг юм. Цагийн сайханд хоббитууд амьдарсан шиг амьдарч, хөгжил баясалтай байдаг байж. Эрээн мяраан голцуу шар, ногоон өнгийн хувцас өмсөнө. Хөлдөө юм углахгүй. Хөлийнх нь тавхай шир шиг хатуу бөгөөд толгойны үс шиг хар, өтгөн үстэй. Гуталчны мэргэжил нэг их нэр хүндтэй биш, харин өөр урлал цэцэглэн хөгжжээ. Хоббитууд жигтэйхэн уран, савх шиг нарийхан хуруутай. Эднүүс хэрэгтэй л юмаа хийнээ, хамгийн гол нь гайхамшигтай юмс хийнэ. Зүс царай нэг их гойд сайхан биш, сэтгэл

сайхан. Гялалзсан хурц нүд, цулцгар хацар, ягаан царайтай. Бараг чихээ хүрсэн том амтай. Ам нь дандаа инээх гээд ч байгаа юм шиг, ууж, идэх гээд ч байгаа юм шиг санагдана. Унан тусан элгээ хөштөл хөхөрдөг, ханатлаа идэж уудаг улс. Идэх юм нь байвал өдөрт зургаан удаа хооллоно. Шоглож хошигнох нь уран гоё биш. Уужуу сайхан сэтгэлтэй хоббитууд нь зочид хүлээн авах их дуртай. Бэлэг сэлт авах бас их дуртай, өгөхдөө ч гар үл татна. Хоббитууд хүн бидний яах аргагүй шууд төрөл садан мөн бөгөөд эльф болон анахай нартай ч жишихийн аргагүй ойрын төрөл. Эртнээс нааш өөрсдийнхөөрөө өөрчилсөн хүний хэлээр ярьсаар ирсэн бөгөөд олон талаараа хүнтэй адилхан. Гэхдээ бидний ямар төрөл болохыг одоо тодруулж чадахгүй. Хоббитууд бол Эхлэлийн өмнөх үеийн аль дивангарын бүтээл. Өнгөрсөн завхарсан тэр үеийн бичмэл үлгэр домгуудыг ганцхан эльфүүд л хадгалж байна. Тэдгээрт хүмүүс өөрсдийн тухай бага дурдаад, хоббитуудын тухай бүр ор тас дурдаагүй байдаг. Хоббитууд ийнхүү хэнд ч үл анзаарагдан Дундад газарт олон зуун жил тааваараа аж төрж байжээ. Хорвоо дэлхий гэдэг хачин сонин юмаар дүүрэн байдаг болохоор юун энэ муусайн газрын бэтэгнүүдийг ажиглахтай манатай.

Тэгтэл Бильбо болон түүний өв залгамжлагч Фродог амьд сэрүүн байхад тэд өөрсдөө мэдэгдье гээгүй байтал гэв гэнэт бүхэнд чухал, бүхэнд тодорхой болж, тэдний тухай Мэргэд болон Эздийн Зөвлөлүүд дээр яриад эхэлжээ. Дундад газрын гурав дахь үе аль хэзээ өнгөрч, дэлхий одоо тэр үеийнхээс шал өөр болсон ч хоббитууд урьдын аж төрж байсан Хуучин ертөнцийн баруун хойно, Далайгаас дорно тийш суусаар байна. Эд нар хаанаас гараад ирсэн, анхлан хаана амьдарч байсныг Бильбогийн үед ч мэддэг хүн нэг ч байсангүй. Эрдэм ухааныг нэг их хүндэтгэдэггүй байсан боловч дээр үед гэр орондоо урьдын адил хоббит ном судраа унших төдийгүй эрт урьдын тухай, эльфүүд, анахай нар болон хүмүүсийн алс холын орны тухай таньж мэдэх заншилтай байв. Эдний өөрсдийн он тооллын бичиг Хоббитуудын суурьшсан цагаас эхэлсэн бөгөөд хамгийн эртний домгууд нь хэсүүчлэлийн өдрүүдээс эртгүй үед холбогдож байна. Гэхдээ энэ домог, зарим үг хэллэг, зан заншлаас мөшгөн үзвэл хоббитууд бусад ард түмний адил нэгэн цагт дорно дахинаас ирсэн нь тодорхой байна.

Эртний домгууд нь тэдний Андуйн мөрний эхний тэгш газарт Аугаа их Бөглүүд ой, Манант уул хоёрын завсарт сууж байсан үеийнх нь ул мөр бүдэг бадаг хадгалагдан үлджээ. Тэгтэл яагаад уулсаар дамжин бартаатай, осолтой газар бууж ирж, Эриадорт гарсан нь одоо ойлгомжгүй байна. Эргэн тойронд хүн олноор суурьшсан, битүү ойд ямар нэгэн таагүй зүйл нүүрлэсэн, ингээд дүнсгэр их ойг Лихомсы хэмээн шинээр нэрлэх болсныг тэнд дурьдсан байна. Уул дамжин нүүдэллэхээс өмнө лапитууд, хулчгарууд, чандаганууд гэсэн гурван овгийн хоббит байжээ. Лапитууд нь арай бараан царайтай, арай жижиг биетэй, сахал тавьдаггүй, хөлдөө юм өмсдөггүй байв. Эдний гар хөл чанга бөгөөд голцуу ууланд, уулын хяраар сууна. Хулчгарууд нь бие тагжгар чийрэг, гар хөл том бөгөөд тэгш газар голын хөндийгөөр сууна. Чандаганууд нь царай цайвар, үс шаргал, бусдыгаа бодвол бие өндөр чилгэр бөгөөд ой модон дотор байх их дуртай. Лапитууд дээр үед анахайнуудтай эв найртай байж, уулсын дэвсэгт удаан суурьшжээ. Холын садангууд нь нам гүмхэн орон газраа орхихыг ч бодоогүй байхад тэд өрнө зүг хөдөлж, Цуурайт уулын хавьд Эриадорт төөрчээ.

Хамгийн хэвийн, хамгийн зөв нүх ухах, газар доогуур нүхлэх өвөг дээдсийнхээ заншлыг хамгийн удаан хадгалсан хоббитууд нь эднүүс юм. Хулчгарууд бүр эртнээс Андуйн хэмээх их мөрний эргээр сууж, тэндэхийн хүмүүст дасчээ. Эднүүс лапитуудын араас өрнө зүг

хөдөлсөн боловч Албинт голыг даган өрнө зүг эргэжээ. Олонхи нь Тарбадын гармаас Сирийн тэгш тал хүртэл тархан нутаглав. Чандаганууд бол умрын өвөг бөгөөд хамгийн цөөн тоотой нь юм. Тэд бусдыгаа бодвол эльфүүдтэй их ойр дотно байжээ. Уран дархны ажлаас үлгэр домог, дуу хуурыг илүүд үзнэ. Газар тариалан эрхлэхээс ан гөрөө хийхийг эрхэмлэнэ. Тэд уулсын дунд хэсгээс нэлээн хойгуур даваад Эриадорт ирээд, дэмий удалгүй өөр овгийн шинээр суурьшсан хоббитуудтай холилдов. Бусад овгийнхноо бодвол зоримог, авхаалжтай болохоор заримдаа хувь заяаны эрхээр хулчгарууд болон лапитуудын удирдагч болон омгийн ахлагч болгочихдог байв. Манант болон Сарны уулсын хооронд хоббитууд эльфүүдтэй ч, хүмүүстэй ч тааралджээ.

Тэр үед энд өрнийн цаад биеэс далайгаар ирэгсдийн ихэмсэг үр удам болох дунаданчууд амьдарч байсан билээ. Гэхдээ эднүүс улам бүр цөөрч, Умрын Вант улс аажимдаа эвдэрхий балгас болж байв. Шинээр ирсэн хоббитуудыг ердөө хавчиж хяхаж, гадуурхсангүй, нутаг хүрэлцээтэй байсан болохоор шинэ нутагт тэд дорхноо идээшив. Бильбогийн үе гэхэд анх суурьшсан хоббитуудын дийлэнх нь ул мөргүй алга болжээ. Гэхдээ тэднээс ямар ч байсан үлдсэн нь чухал юм. Хоббитууд урьдын адил уул бараадаж, бас Хоббитаний гол сууринаас дорно тийш дөчин бээрийн газар Чемборын ойд амьдарч байлаа. Тэр эрт балар цагт хоббитууд дунаданчууд шиг бичиг үсэгтэй байх ёстой байв. Дунаданчууд бичиг үсгээ эльфүүдээс авсан юм. Тэд удалгүй хуучин хэлээ мартаж, Арнораас Гондор хүртэл, Алтлаг эргээс Цэнхэр уулс хүртэлх далайн нийт эргээр тархсан бүх нийтийн хэлээр ярих болов. Гэхдээ хоббитууд сарын нэр, гараг, өдрийн нэр гээд цааш нь олон юмны нэрийг хадгалан үлджээ. Яваандаа түүх домгийг орлож, харин он цагийн тоолол тоо томшгүй зуунуудыг орлож байна. Учир нь гурав дахь эриний мянга зургаан зуун нэгэн онд Марчо, Бланка гэдэг ах дүү хоёр хулчгар Форпост дахь их ноёноос зөвшөөрөл авч (Гондорын он тооллын бичгээр бол энэ Арведуйн ноёрхолд гурван зуун жил болоод мөхсөн умрын улсын хорьдугаар ноён хоёрдугаар Аргелеб байжээ) Уулсын дэвсгээ орхиод үй олон хоббитуудыг толгойлон явж, ширүүн урсгалт, их уст Барандуйн голыг гаталжээ. Тэд энэ голыг Умрын Вант улсын сайн цагт барьсан Их Чулуун гүүрээр гарч, өрнийн довцог хүртэлх гол дагуу газраар тархжээ. Тэднээс ердөө Их гүүрийг засч өгөхийг л шаардаад бусад зам, гүүрээ зохих журмын дагуу хамгаалжээ. Харин ноёныг өөрсдийн дээд эзэн гэж үзээд, ноёны элч нарыг нэвтрүүлж байв.

Хоббитуудын он тоолол чухамхүү эндээс эхэлдэг. Учир нь Брендидиум (Хоббитууд голын нэрийг ийнхүү хазгай дууддаг байв)-ийг гаталсан жил Хоббитануудын хувьд Анхны жил, цаашдын тооллын зааг (Эльфүүд болон хүмүүсийн он тоолол дахь гурав дахь эриний он нь ийнхүү хоббитуудын он дээр 1600 нэмэх замаар мэдэгддэг) болсон юм. (зохиогчийн тайлбар). Өрнийн хоббитууд шинээр олж авсан газар нутгаа ихэд хайрлаж, нутгийн зах хязгаараас гардаггүй байв. Тэгтэл хүмүүсийн болон эльфүүдийн түүхээс төдхөн дахиад алга болов. Эднүүс ноёны харьяат гэгдэж байсан ажил хэргийг нь өөр өөрийнх нь удирдагч хариуцдаг байв. Ийнхүү тэд бусдын хэрэгт хошуу дүрдэггүй байлаа. Форностыг Ангмарын илбэч ноёнттой сүүлчийн удаа дайтахаар зэвсэглэн бэлтгэхэд хоббитууд ноёнд туслахаар харваачдын отряд илгээсэн гэх боловч хүмүүсийн он тооллын бичгүүд үүнийг нотлохгүй байна. Энэ дайнд Умрын Вант улс ялагдаж, тэр цагаас хойш хоббитууд бэлгэнд ирсэн газар нутгийнхаа бүрэн эзэн нь болж, удирдагчдынхаа дотроос ноён бөлгөөгийнхөө жанжин сайд болгож өөрийн Хоббитаныг сонгов. 37 оны Хар Үхлийн салхи сэвэлзэхийг мэдэрч дайны бүхэл бүтэн мянган жилийг тойрч гарсан.

Тэд урт өвөл болж, дараа нь аюумшигт өлсгөлөн залгах хүртэл төрж, өсч үржсэн. Олон мянга нь өлбөрч үхсэн боловч биднийг энэ тухай ярьж буй энэ цаг үед тэр өлсгөлөнгийн өдрүүд аль хэдийн түүх болон хоцорч, хоббитууд дахин элбэг дэлбэг амьдралд дасчээ. Эхлээд хаягдсан газар авсан боловч эдний нутаг өгөөмөр, баян хангай байлаа. Эхлээд газраа тун сайн боловсруулснаар эдэлбэр газар болон тариалангийн талбай, цэцэрлэг болон жимс жимсгэний талбайнууд ноёны аж ахуйч нүдийг баясгаж байжээ. Эдний газар нутаг дорноос өрнө, өрнийн довцог толгодоос Брендидуимын гүүр хүртэл дөчин лиг, умрын балчиг шавраас өмнийн намаг хүртэл тавин лиг үргэлжилсэн байдаг. Энэ бүхнийг Хоббитани гэж нэрлэх болжээ. Хоббитууд газар нутгийнхаа хил заагийн гаднах тааламжгүй байдлыг үл ажааран амьдралаа өөрийнхөөрөө зүгшрүүлж, амар амгалан, сэтгэл өег байх нь Газар дундын оршин суугчдын ердийн хувь заяа мөн, үүнээс өөрөөр байх ёсгүй гэж үзэж, үүндээ дасчээ. Тэд манаач нар буюу баруун хойд хэсэгт эхнийг сахиулагчдын цэрэг дайны ажиллагааны талаар мэддэг байсан жаал жуул юмаа мартсан уу, яасан. Хоббитууд тэдний өмгөөлөл дор нэгдээд энэ талаар бодохоо ч больжээ. Хоббитуудад цэрэг дайны асуудал байдаггүй, эднүүс хоорондоо хэзээ ч дайсагналцаж байсангүй. Тухайн үедээ тэдэнд манай ертөнцөд байдаг шиг өөрийгөө өмөөрөх хэрэг гардаг байсан нь мэдээж, гэхдээ энэ Бильбогийн үед нэгэнт аль дивангарын өнгөрсөн завхарсан юм болсон байв.

Халдан довтолсон Орхуудыг Ногоон талд 1147 онд Брандобрас хиартал цохисон юм. Хоббитуудын нутагт болсон цорын ганц энэ тулалдаан ч одоо домог болжээ. Тэр үеийн цаг уур ч зөөлөрчээ. Умраас дайрдаг чоносын түйвээн эмээгийн үлгэр болов. Хоббитани нутагт ямар нэгэн зэр зэвсгийн зүйлийг айлын хананд задгай зуухны дээр, аль эсвэл ухмал газар, хотын музейн тоос шороонд дарагдсан хог новшин дотор үзэж болно. Энэ музейг хогийн амбаар гэдэг. Яагаад гэвэл хийе гэхээр хийх газар олдохгүй, хаях гэхээр хайран санагддаг юмаа хоббитууд хог гэнэ. Ийм хог тэдний гэр оронд нэлээн байх бөгөөд гараас гар дамжсан бэлэг дурсгалын зүйл ч олон байх. Гэхдээ элбэг дэлбэг, амар тайван амьдрал энэ хүний хугасуудыг яагаад ч юм бэ, тийм ч эрх танхи болгочихсонгүй.

Хоббитыг айлгах, тэр тусмаа сэтгэлээр унагаж гутраах гэдэг даанч амаргүй. Газрын амьдралын сайн сайханд хайртай ч бас тэднийг амсаж эдлэлгүйгээр зовлон, гачигдал, амьдралын хатуу хөтүүг ажрахгүй туулж чаддаг болоод тэр буй заа. Харах царайнаасаа хэтийдсэн амьтад шүү. Зодолдож нүдэлдэхгүй, ан гөрөөг тэгтлээ их сонирхдоггүй мөртлөө аюулын өмнө сандарч барьц алдана гэж огт үгүй, зэвсэг хэрэглэхээс төсөөрнө гэж бас огт үгүй. Хараа хурц, гар чийрэг болохоороо нум харвахдаа мэргэн. Хоббит чулууны цаагуур суун тусвал ямар ч араатан ум хумгүй зугтахаа мэднэ. Дээр үед хоббитууд бүгдээрээ дор дороо нүх ухдаг байсан гэж домогт өгүүлдэг. Тэд газар доор хамгийн найдвартай гэж одоо ч үздэг. Гэхдээ цаг ирэх тусам өөр байр оромжинд дасч байна. Чухмыг хэлэхэд Бильбогийн үед хамгийн баян, хамгийн ядуу хоббитууд л хуучнаараа аж төрж байсан. Ядуус нь ганц онигор цонхтой юм уу эсвэл цонхгүй бүдүүлэг газар гэр буюу жинхэнэ нүхэнд шахцалдан суудаг байв.

Мөн нэлээн бэл бэнчинтэй чинээлэг зарим нь эртний уламжлалаа хүндэтгэж газар доор орд их гэр барьдаг байв. Олон салаалсан өргөн хонгилтой газар доорх орд их гэр барихад хаа тааралдсан газар болгон тохирдоггүй. Хоббитууд нам дор газар, газар дээр орон байраа барих болов. Норгорд ч юмуу Кроли, Хоббитаны төв хот Саруул дэвсэг дээрх Ухмал газар хот зэрэг

уулархаг хэсгийн хуучин суурингуудад мод, тоосго, чулуун барилга босох болов. Ийм барилгадаа ялангуяа тээрэмчин, төмрийн дархан, тэрэгчин зэрэг дархан, мужааны ажилчдад гойд зохистой байжээ. Тэр байтугай газар нүхэнд амьдардаг хоббитууд хүртэл дээр үеэс саравч, дархны газар барьж байв. Ферм, амбаар барих заншил Брендидуимын их намагт анх үүссэн мэтээр ярьдаг.

Тэр үеийн хоббитууд болох Дорнын харъяат нутгийн оршин суугчид бие бадриун, хөл том улс байсан бөгөөд хур тунадастай үед шаахай өмсдөг байв. Гэхдээ тэд хулчгаруудаас гаралтай нь тодорхой хэрэг. Бараг бүгдийнх нь эрүү тэр аяараа үс сахалдаа баригдсан байдаг нь учир утгагүй зүйл биш. Лапитуууд ч, Чандагууд ч хэн нь ч эрүүндээ сахалгүй. Брендидуимаас дорно тийш намаг болон Туулайн толгод руу хоббитууд өмнө зүгээс олноороо үнэхээр тусдаа иржээ. Тэдний хэлэнд хачин сонин этгээд нэрс үлджээ. Бас хоббитануудын нутагт дуулдаагүй үгсийг ч хэлж байх аж. Хоббитууд дунаданчуудаас олон юм сурсны нэг нь барилга барих ажил байсан нь магадтай байна. Гэхдээ хүмүүсийн анхны багш - эльфүүдээс шууд сурч болох байсан. Тэгэхэд эльфүүд Газар дундыг орхио ч үгүй, Мөнгөлөг Боомтын ойролцоо өрнө зүгт байсан үе. Зөвхөн энд ч биш хоббитуудын нутагт тун ойрхон сууж байв. Баруун хилийн намгийн цаад биеийн цамхагт ууланд эльфүүдийн гурван цамхаг бүүр аль эртнээс сүндэрлэн боссон ажээ.

Сарын саруудд гялалзаж байна. Хамгийн өндөр нь цаад талдаа юм. Ногоон овоон дээр сүүхийнэ. Энэ цамхагийн орой дээрээс далай харагддаг гэж Баруун нутгийн эльфүүд ярьдаг юм. Тэгтэл эл цамхагын орой дээр гарсан хоббит нэг ч үгүй байгаа юм. Ер нь далай үзсэн хоббит тоотойхон. Ганц хоёр нь далайгаар сэлсэн байх, тэгэхдээ энэ талаар огт ярьдаггүй. Далай далай л гэнэ, горхи, завинаас ч мань хоббитууд их айж цэрвэдэг мөртлөө яагаад ч юм нэг нь сэлсэн гээд байдаг юм. Далай гэдэг тэдний хувьд үхэл санагдуулсан аймшигт үг болжээ. Тийм болохоор баруун нутгийн толгодоос харц буруулдаг.

Юм барьж босгохыг эднүүс эльфүүдээс сурсангүй, хүмүүсээс ч сурсангүй ердөөсөө өөрсдийнхөөрөө л барьжээ. Тэдэнд цамхагийн хэрэг байсангүй. Харин урт намхан тохилог байр хэрэгтэй байсан юм. Хамгийн эртнийх нь газраас цухуйж байгаа юм шиг навтгар юмнууд байх. Түүнийгээ өвс, сүрэл юм уу хүлрийн наалдангиар хучсан байдаг. Хоббитуудын нутагт анхландаа л ингэж барьдаг байжээ. Сүүл сүүлдээ өөрчлөгдөж, засарсаар засарсаар боловсронгуй болжээ. Үүнд анахай нарын ач тус бий, өөрсдийнх нь хичээл зүтгэл ч бий. Хоббитуудын барилга дугуй цонх, дугуй хаалгатайгаараа онцлог. Байр, газар гэртэй айлыг Хоббит нутагт чинээлэгт тооцдог бөгөөд байр, газар гэрт ам бүл олуул, өнөр айл суудаг.

Бильбо, Фродо Торбинс гээд гоонь эрчүүд байсан. Том Смиалын Кролууд ч юм уу, Хоромин - Брендидуимын Брендизайкууд шиг төрөл төрөгсдийн олон үе өвөг дээдсийнхээ нүхэн гэрт юмуу, газарт наалдсан тагзанд суудаг байсан. Нэг их эвтэй найртай суудаг байсан гэж хэлэхгүй. Дашрамд дурдахад хоббитууд гойд төрхөмсүү олон түмэн шүү дээ. Ураг удмаа их сайн мэднэ. Урт урт мөчиртэй, ургийн мод зурсан байх. Хэн хэнтэй төрөл, чухам ямар төрөл болохоо мэдэх нь хамгийн чухал. Бид тэр ургийн модыг номдоо зурах ямар ч боломжгүй, тэр бүү хэл хамгийн гол гол өрх бүлийг нь тэмдэглэе ч гэсэн бололцоо байхгүй. Ерөөсөө ямар ч номд багтахгүй. Баруун хязгаарын Улаан Номын эцэст байгаа ургийн модод нь тэр аяараа нэг ном гэсэн үг. Түүнийг хоббитуудаас өөр хэн ч, хэзээ ч шагайж хараагүй. Мэдэж байгаа юм нь

номд байгаасай, байх байхдаа энгийн тодорхой, ямар ч будлиангүй байгаасай гэж хоббитууд хүсдэг. Ер нь өөртөө үнэнч байгаа бол зөвхөн энэ л хангалттай.

Гаансны өвсний тухай

Хоббитуудын тухай бас өөр яримаар юм байна аа. Бүр эрт дээр үеэс уламжилж ирсэн нэг хачин заншилтай. Тэр нь юу вэ гэхээр “Гаансны өвс” гэдэг навчийг шавар юм уу, модон гаансаар татдаг юм. Үүнийг зүгээр өвс л гэнэ. Энэ нь никотиний төрөл юм шиг байгаа юм. Хоббитуудын нэрлэдгээр энэ “урлаг” буюу этгээд гажуу заншлын үүсэл нь даанч нууц. Дээр үеэс илрүүлсээр ирсэн бүхнийг нь Мериадок Брендизайк (сүүлд Забренийн удирдагч болсон) цуглуулсан ажээ. Өмнөд хязгаарын тамхи бидний туужид нэлээд үүрэгтэй учраас түүний “Хоббитан нутгийн өвс”-ний удиртгалыг эшлэх хэрэгтэй боллоо. “Энэ бол бидний өөрсдийн бүтээсэн гэж баттайаа хэлэхээс өөр аргагүй цорын ганц урлаг юм. Хоббитууд хэзээ татаж эхэлсэн нь тодорхойгүй. Манай үлгэр домог, өрх бүлийн үүх түүхэнд гарч байгаагаар бол хоббитууд өмхий болон анхилуун үнэртэй янз бүрийн өвсийг олон зууны турш татсаар иржээ. Урт сүүлтийн Тобольд Уромобой Хоёрдугаар Изенгримийн үед буюу Хоббитуудын тооллоор 1070 оны орчим (Л. Х) өмнөд хязгаарт ногооны талбайдаа анх удаа гаансны өвс тарьж ургуулсан гэдэг мэдээ он дарааллын бичиг болгонд байна. Энэ шилдэг өвс одоо ч тэндээ ургаж байгаа бөгөөд “Урт сүүлтийн өвс”, “Хөгшин Тоби”, “Өмнийн од” гэдэг нэрээр одоо ихээхэн алдаршжээ. Хөгшин Тоби энэ ургамлыг яаж үнэрлэдэг байсан нь тодорхой бус. Үхэх гэж байхдаа ч юу ч хэлсэнгүй.

Олон газраар яваагүй мөртлөө өвсийг мэддэг хүн байж. Залуудаа байн байн Довцог ордог байсан гэлцдэг юм. Довцогоос цааш хаашаа ч яваагүй гэсэн үг. Довцог дээр гарч энэ ургамлаа эрдэг байсан байж болох нь их магадтай. Одоо тэр өвс өмнийн уулсаар ургаж байна. Гаансны өвсийг татаж үзье гэдэг санаа анх бидний толгойд орж ирсэн гэж Довцогийн хоббитууд батлан өгүүлдэг. Эднүүс ер нь юм болгонд хоббитуудын нутагт суугчдыг давах гэж оролддог, тэр байтугай нүүн суурьшигчид гэдэг юм. Гэхдээ энэ тохиолдолд тэднийг нэг их буруутгах аргагүй. Жинхэнэ өвсийг татах урлаг Довцогт үүссэн нь эргэлзээгүй. Эндээсээ анахай нар болон мөрдөгчид, илбэчид зэрэг бусад хэсүүлчдийн дунд тархжээ. Эртний замын энэ бэлчир дээр одоо ч гэсэн тал талаасаа цуглардаг хэрмэл тэнүүлчдийн дунд дэлгэрэв. Дээр дурдсан урлагийн тархалтын анхны эх бөгөөд төв нь Наркиссынхны гэр бүлээрээ эрт дээр үеэс ажиллуулж ирсэн эртний довцогийн “Цахилж яваа одой морь” гэдэг гуанз мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Өмнө зүг нэг бус удаа аялах үедээ миний ажигласан зүйлс энэ татаж болдог өвс зөвхөн манай нутагт төдийгүй Андуйны нам дор газарт ч ургадаг юм гэдэгт намайг итгүүлсэн. Баруун хязгаарын хүмүүс далайгаар авч явж, Андуйны нам дор газар хүргэсэн нь мэдээж. Одоо Гондорын нутгуудаар хаа сайгүй ургаж байна. Умардынхантай жишихийн аргагүй бүрэн тарималжсан өтгөн сахлаг ургаж байна.

Гэхдээ Умардынхан шиг илч дулаан, арчилгаа тордлого шаарддаг. Гондорынхон үүнийгээ “Амтат тамхи” гэх бөгөөд цэцгийн сайхан үнэрийг нь ихэд үнэлдэг. Тэндээс тэр ургамлыг бартаат замаар Элендилийн хаанчлалын үеэс өнөөдрийг хүртэл олон зууны турш манай нутагт оруулж иржээ. Тэгтэл Гондорын дунданчууд энэ өвсийг татахыг анх санаачлагчид нь хоббитууд гэж зөвшөөрдөг. Илбэ шидтэнгүүд бодож олоогүй л байгаа юм даа. Манай урлагаас гажихгүй нэг илбэ шидтэнг би мэдэх юм. Тэр ямар ч юмыг амжуулдаг шиг хоцрохгүй сураад авсан байна билээ.

Хоббитан нутгийн тохижилтын тухай

Хоббитан нутаг Умар, Өмнө, Өрнө, Дорно гэсэн дөрвөн хязгаарт хуваагджээ. Хязгаарууд нь нутгийн хамгийн дээр үеийн, нэр хүндтэй дээдсийнхээ нэрэмжит тойргуудад хуваагдана. Энэ удмынхны үр сад нь одоо Хоббитан нутгийн өөр хэсэгт байсан ч хамаагүй. Бараг бүх Ноён хуучнаараа Укрольд суудаг. Харин Торбинс, Булкинсүүдийн хувьд арай өөр. Хязгааруудаас гадна бас Дорнын, өрнийн нүүн суурьшигчид нь Туулайн Толгодынхон бөгөөд өрнийн нүүн суурьшигчид нь 1164 онд (Л.Х) Хоббитан нутагт шилжүүлжээ. Одоо бидний ярьж байгаа тэр элэр балар цагт Хоббитанд “Засгийн газар” гэх юм бараг юу ч байгаагүй. Овог төрөл тус бүр өөр өөрийнхөө хэрээр дор дорынхоо юмыг хийгээд болоод явдаг. Гол ажил нь арвин ургац авах, амт чанартай хоол унд идэж уух. Хоббитууд ер нь нэлээн эелдэг зантай, ямар ч шуналгүй. Өөрт байгаа юмандаа сэтгэл өег, бусдын юмыг илүү хардаггүй. Газар ферм, дархны газар болон эздийн газраа солихгүй, ердөө үг хэлгүй өвлөгдөөд шилжээд явна. Форностод эрт дээр үеэс нэгэн их ноён байсан гэдгийг сайн тогтоожээ. Бас хоббитуудыг нутгаас нь умар тийш шахаж Умард гэж өөрчлөн нэрлэснийг тогтоожээ. Тэгэхэд ноён нас бараад мянган жил ч болоогүй байхад Ноёны умардууд устаж алга болоод туурь нь өвс ногоонд дарагджээ. Гэтэл хоббитууд бахь байдгаараа зэрлэг араатны тухай, ноён хэрэггүй тухай ярьж байлаа. Тэд эртний тэр ноёноос бүхий л хууль дүрмээ авч, хууль бол хамгийн зөв дүрэм, тэр тусмаа эртний, шударга учраас сайн дураараа сахин биелүүлдэг байв. Ноёд бол бүр эрт дээр үеэс хоббитуудын нэн эртний овог төрөл байжээ. Хоббитан гэдэг цол хэргэм эднүүст Побегайкуудаас олон зуун жилийн өмнө шилжсэн бөгөөд тэр цагаас хойш овгийн ахлагч Ноён тэр цол хэргэмийг хэлбэрэлтгүй хадгалж явав.

Хоббитан бүх нийтийн хурлыг даргална, журамт цэргийг удирдана, гэхдээ аюул ослын үед л журамт цэрэг хэрэгтэй. Ийм тохиолдол гараагүй мөн ч их уджээ. Хоббитан гэдэг цол ердөө хүндэтгэлийн тэмдэг болжээ. Ноёны овгийнхон их олноос гадна гойд баян болохоороо ихээхэн нэр хүндтэй байв. Үе үе болгонд онцгой ухаантай, шантрашгүй зоригтой ноёд төрж байжээ. Эднүүсийн ийм чанарыг мэддэг хэрнээ ойшоодоггүй байв. Гэхдээ овгийн ахлагчийн журам ёсоороо Хоббитан даяараа Манай Ноён гэх бөгөөд хэрэг гарвал нэрийнх нь өмнө тоо хэлнэ. Жишээлбэл: Хоёрдугаар Изенгрим. Хэрэг дээрээ ухмал газар хотын тэргүүн л цорын ганц эрх мэдэлтэн байлаа. Саруул өндөрлөгт чөлөөт яармаг болох үеэр долоон жил нэг удаа дахин сонгоно. Жилийг хоёр хуваасан зуны энэ гурав, дөрвөн өдрийг хоббитууд “Наалдац” гэдэг. Хотын дарга хоббитуудын дунд олонтаа болдог баярт зориулсан том том найрыг удирдах ёстой. Гэхдээ үүний дээр Шуудангийн хэрэг эрхлэх газрын дарга болох Ширрифүүдийн ахлагчийн үүргийг засдаг байв. Илгээлт хүргэх ажил түүний үүрэгт ордог. Бас ёс зүйн захиргааг хамаарна. Хоббитанд энэ хоёроос өөр үйлчилгээ байхгүй. Илгээлт нь ёс зүйгээсээ хавьгүй их ажилтай. Хоббит болгон бичиг үсэг мэдэхгүй, мэддэг нь найз нөхөддөө бүгдэд нь бичнэ. Нутаг холдоод эргэж очиж чадахгүй төрөл төрөгсөддөө бичдэг.

Хоббитууд харуул хамгаалалтаа ”ширриф” гэдэг байв. Тэднийг эргүүл харуулын ажлыг оромдогчид гэвэл илүү оновчтой байх. Мэдээж, тэд дүрэмт хувцас өмсдөггүй (энэ талаар тэдэнд ямар ч ойлголт байхгүй). Малгадаа нэг өд хатгаад л болох нь тэр, эргүүл харуул гэхээсээ манаач л байсан юм. Тэд хүмүүсийг биш, амьтдыг л хардаг байлаа. Ердөө л арван хоёр ширриф, тойрог бүрт гурав гурван ширриф байсан, тэд тойргийнхоо л ажлыг хийнэ.

Тэднээс гадна тодорхойгүй тооны хүнтэй нэготряд байсан нь ямар ч харийнхан, үлэмж биетнүүд байна уу, өөдөс биетнүүд байна уу хамаагүй, Хоббитан оронд элдэв хэрэг төвөг тарихгүй байхын тулд “хил хязгаар тойрох” үүрэгтэй байв.

Манай тууж эхэлж байсан тэр үед шургалагчид хэмээх урилгагүй зочид тасардаггүй байв. Хоббитаны дөрвөн тойрог хил орчмоор доншуучилж, байн байн хил зөрчих болсон урьд өмнө үзэгдэж харагдаагүй араатнууд болон учир нь үл ойлгогдох харийнхны тухай үзсэн дуулснаа өөр хоорондоо мэдээлдэг байлаа. Элдэв юмнууд хил орчмоор үзэгдэх болсон нь амьдрал явах ёстой жамаараа, цаг ямагт байснаараа явахгүй, нэг л биш болж байгаагийн эхний шинж тэмдэг байв. Аль эрт мартагдсан тэр сайхан цагийг зөвхөн хамгийн эртний домгууд л сануулж байв.

Тэр үед чухам юу гээч болоод байгааг хэн ч ойлгохгүй, бүр Бильбо өөрөө ч ойлгохгүй байв. Тэрбээр мөнөөх дурсамжит аялалдаа гарснаас хойш жаран он улирч, зуу насалдаг хоббитуудын тооллоор ч гэсэн мань эр өтөлсөн байлаа. Гэвч түүний авчирсан баялаг барагдаагүй нь илт байсан юм. Одоо түүнд хэр их баялаг үлдсэнийг тэр хэнбугайд ч, хайртай үеэл дүү Фрододоо ч хэлээгүй билээ. Мөн ямар ч бөгжний тухай хэл сураг гараагүй байв.

Бөгжний эзэн / Бөгжний ахан дүүс

Хоббитан сударт өгүүлснээр, нэг удаа Бильбогийн агуу их шидтэн Саарал Гэндалф ирэхдээ арван гурван гном буюу хөөгдсөн хаан Царсбамбай Торинг арван хоёр дагуултай нь дагуулж иржээ. 1341 оны дөрөвдүгээр сарын нэг өглөө Бильбо Бэлийн эзэнт оронд олон зуун жил хураасан хэмжээлшгүй их эрдэнэсийг гномуудад олж өгөхөөр алс дорно зүг рүү өөрөө ч гайхмаар гэнэтийн аялалд гарчээ. Түүнийг азын тэнгэр ивээж, эрдэнэсийг манаж байсан лууг дарж чадсан байна. Таван их дайчны тулаанд Торин баатарлагаар амь үрэгдэж, олон олон гавьяа байгуулсан боловч тэр их тулааны талаар Гуравдагч галавын урт түүхэн бичигт ердөө замд санамсаргүй гэсэн мэт хоёрхон мөр л үлджээ.

Түнэр Бөглүүд орох замд Манант уулнаа явж байх үест аянчид руу орхууд довтолж, Бильбо өөрийнхнөөсөө хоцрон харанхуй хар ангалд төөрчээ. Мөлхөж яваад ямар нэг бөгж гарт нь тэмтрэгдэхэд юун бөгж вэ гэж бодсон ч үгүй зүгээр л тохиолдлын олз шиг халаасандаа хийчихжээ.

Гарах зам эрсээр байгаад тэр уулын хамгийн гүн рүү орж Хүйтэн нууранд хүрэв. Тэр нуурын дундах чулуун арал дээр хүйтэн оч хаялсан цийлгэр нүдтэй Хорлум хэмээх бузар амьтан байдаг байж. Тэр хавтгай ёроолт завинд сууж, хавтгай өргөн тавхайгаараа сэлүүрдэн урт хумстай сарвугаараа сохор загас барьж амьдаар нь иддэг байж. Тэр ямар ч хамаагүй амьтан барьж иддэг, дийлж л байвал орхуудыг ч хамаагүй багалзуурдаж алаад идчихдэг байжээ. Түүнд нэг нууц эрдэнэ байсан нь газар дээр амьдардаг байхдаа олж авсан шидэт алтан бөгж байв. Тэр бөгжийг зүүхээр үзэгдэхгүй болдог байжээ. Хорлум хорвоо дээр зөвхөн тэрэндээ л хайртай, тэрнийгээ “миний эрдэнэ” гэдэг, хуруундаа зүүгээгүй, гартаа атгаагүй ч байсан тэрэнтэйгээ ярьдаг байжээ. Тэр бөгжөө хадан арал дээр хаа нэгтээ хадгалдаг, зөвхөн орх алж идэх болохоороо л зүүдэг байв.

Хорлумын гарт бөгж нь байсан бол Бильбо руу шууд л дайрах байлаа. Даанч бөгж нь байсангүй. Харин Бильбод илд болсон эльф кинжаал байлаа. Тиймээс цаг хожихын тулд Хорлум оньсого таалцах санал тавив. Хэрэв Хорлумын оньсогыг Бильбо таахгүй бол Хорлум Бильбог алж иднэ, эсвэл Бильбогийн оньсогыг Хорлум таахгүй бол Хорлум Бильбог газар дээр гаргаж өгнө гэж мөрийцөв.

Бильбо зөвшөөрөхөөс өөр арга байсангүй, амьд гарах найдваргүй төөрснөөс амиараа дэнчин тавьсан нь арай л дээр байсан тул олон олон оньсого таалцав. Эцэст нь Бильбо яллаа, энэ удаад ч гэсэн түүнийг ухаан сэхээ нь биш, тохиолдол аварлаа. Тэр таахын аргагүй оньсого хэлэх санаатай түгдэрч байхдаа яагаад ч юм халаасандаа гараа хийхдээ аль түрүүн олоод тэр дороо мартчихсан бөгж гарт нь тэмтрэгдэхэд “Миний халаасанд юу байна?” гэхэд нь Хорлум гурван хувилбар хэлээд ч таасангүй.

Энэ асуулт тоглоомын хатуу дүрэмд нийцсэн оньсого мөн эсэх талаар санал зөрөлдөөн байдаг боловч нэгэнт Хорлум таах гэж оролдсон л бол тохиролцоогоо биелүүлэх ёстой гэж бүгд санал нэгддэг юм. Ийм тохиролцоог эртнээс нааш хамгийн адгийн муухай амьтдаас бусад нь ариун нандин гэж үзсээр ирсэн боловч Бильбо энэ хогийн новш намайг мэхэлчих байх гэж огт бодолгүйгээр тохиролцоогоо биелүүлэхийг шаарджээ. Гэвч хав харанхуйд гав

ганцаараа олон жил өнгөрөөсөн Хорлумын сэтгэл зүрх пад хар болсон тул хэлсэн үгээсээ буцах гэдэг түүнд юу ч биш байлаа. Тэр Бильбог мэл гайхуулан орхиод эргээс холгүй хадан арал руугаа сэлж одов. Бөгжөө авах гэсэн нь тэр байж л дээ. Тэр өлөн ч байж, ууртай ч байж, “шидэт бөгжөө угласан цагт нэг муу хутганаас юундаа айх вэ” гэж бодож.

Гэвч бөгж нь байсангүй, оргүй алга болсон байв. Хорлум хачин муухай хашгирахад Бильбо эхлээд учрыг нь олоогүй боловч нуруун дээгүүр нь шоргоолж гүйх шиг болов. Хорлум юу болсныг оройтсон ч гэсэн ойлгожээ. “Тэрний халаасанд юу байна?” гэж тэр хилэнтэйеэ хашгирав. Нүд нь галзуурсан мэт гялалзсаар тэр хоббитийг алж, “эрдэнэ”-ээ авахаар ухаан жолоогүй эргэж хурдлав. Бильбо юу болж байгааг сүүлчийн хоромд ойлгож, байдаг хурдаараа зугтлаа. Дахиад л тохиолдол түүнийг аварч, зугтах зуураа гараа халаасандаа хийтэл мөнөөх бөгж хуруунд нь углагдав. Хорлум түүнийг харсангүй, “хулгайч”-ийг амдаж барихаар хажуугаар нь шурхийн өнгөрөв. Бильбо араас нь болгоомжтой дагахдаа Хорлумын хараал зүхэл, бөгжинд хандсан гомдолт гоншилтоос бүхний учрыг ойлгож, харанхуй дотроос найдварын дөл сүүмэлзэв. Шидэт бөгжтэй болохоор Хорлумаас ч, орхуудаас ч айх хэрэггүй гэж мэдэв.

Тэр хоёр хар уулын зүүн хажуу дахь нууц гарцад хүрэв. Хорлум тэнд отож, сонор чих, сортон хамраа ажиллуулав. Бильбо түүнийг алах гэснээ өрөвдөх сэтгэл дийлэв. Бөгж гарт нь байсан, түүнгүйгээр амьд гарах найдваргүй байсан ч зам дээр нь тээглэсэн заяагүй новшийг алж төвдсөнгүй. Хорлумын дээгүүр харайж гараад гарцаар гүйн гарахад араас нь “Хулгайч, муу хулгайч, үүрд хараал идсэн үхээрийн Торбинс” гэж цөхрөн орилох дуун хадав.

Бильбо энэ үйл явдлыг дагуулууддаа арай өөрөөр ярьсан нь сонин байдаг. Хорлум мөрийгөө алдвал түүнд “нэг бэлэг” өгнө гэсэн, тэгээд мөрийнд алдсан шидэт бөгжөө авах гээд арал дээрээ очтол нэгэн цагт түүнд төрсөн өдрөөр нь бэлэглэсэн тэр бөгж алга болсон байсан. Бильбо тэр бөгжийг олсон гэдгээ мэдсэн, нэгэнт мөрийгөө авсан болохоор тэр бөгжийг эзэмших бүрэн эрхтэй гэж бодсон. Тэртэй тэргүй тэндээс гарах хэрэгтэй байсан учир бөгжний тухай яриагүй, амласан “бэлэг”-нийхээ оронд гарах зам зааж өг гэж Хорлумд шаардсан. Ингэж тэр дурдатгалдаа өөрийн гараар бичсэн, нэг ч үг өөрчлөөгүй. Тэгэхлээр “Улаан ном”-ын эх зохиолд болон бусад эх сурвалжуудад түүний яриа ийм л байдлаар орсон байж таарна. Гэхдээ зарим эх сурвалжид /зохиож ярьсны зэрэгцээ/ жинхэнэ үнэн түүх ч орсон байдаг юм. Түүнийг Фродо юм уу, Сэмийн ярьснаар оруулсан байх, үнэн явдал ямар байсныг тэр хоёр мэдэж байсан, гэвч хөгшин хоббитын гар бичмэлийг засахыг хүсээгүй биз.

Гэндалф бүр эхнээсээ л Бильбогийн энэ ярианд итгээгүй ба бөгжийг ихэд сонирхож байлаа. Тэр Бильбог шалгааж, түүнээс үнэнийг бага багаар шахан гаргаж байсан бөгөөд заримдаа хэрүүл маргаанд тулж байсан боловч агуу шидтэн үнэнийг мэдэхэд энэ зэргийн юм байх ёстой гэж боддог байжээ. Хоббит шууд л худлаа ярьж эхэлсэн нь Гэндалфд хачин санагдаж болгоомжлох болсон байна. Тэгээд ч “бэлэг”-ийн талаар тэр өөрөө зохиож ярих ёсгүй байв. Бильбо хожим нь Хорлум бөгжийг “төрсөн өдрийн бэлэг” гэж бувгнаж байхыг сонсоод их гайхсанаа хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ нь Гэндалфд тун ч хачирхалтай бөгөөд сэжигтэй санагдсан боловч Бильбо бүх үнэнийг түүнээс дахиад олон жил нуусан юм. Үнэн явдал ямар байсныг та энэ туужаас уншиж мэднэ.

Бильбогийн хойшдын паянг бичих шаардлага байхгүй. Тэрбээр орхуудын харуул манааны

хажуугаар харагдалгүй гарч дагуулуудаа гүйцэж очсон ба хожмоо бөгжний ачаар найз гномуудаа нэг бус удаа аварч байсан боловч түүнийг боломжийнхоо хэрээр нууцалж байлаа. Эргэж ирсэн хойноо ч тэр бөгжөөрөө гайхуулж байсангүй, бөгжний талаар зөвхөн Фродо, Гэндалф хоёроос өөр хэн ч мэдэхгүй байсан. Ямар ч гэсэн Бильбо тэгж боддог байлаа. Тэр бичиж эхлээд байсан “Тийшээ ба тэндээс” номынхоо эхний бүлгийг ганцхан Фродод л үзүүлжээ.

Терн гэдэг илдээ задгай зуухны дээр өлгөж, гномууд лууны эрдэнэсээс авч бэлэглэсэн шидэт хөө хуягаа газар ухагчийнхны Хогийн Амбаарт өлгөөд ихийг үзсэн юүдэнтэй аяны цуваа хувцасны шүүгээнд өлгөсөн бөгөөд харин бөгжөө гинжээр тэлээндээ зүгээд өмднийхөө халаасанд авч явдаг байв.

Тэрбээр Хоббитаны тооллын 1342 оны зургадугаар сарын 22-нд тавинхоёр настайдаа эргэж ирсэн ба зуунарваннэгэн насныхаа ойг /1401 он/ тэмдэглэхээр шийдэх хүртэл бүх зүйл амар тайван явагдаж байсан юм. Манай тууж ч тэндээс эхэлнэ.

НЭГДҮГЭЭР ДЭВТЭР

Бүлэг 1

Удаан хүлээсэн дайллага

Уутан Хясааны эзэн Бильбо Торбинс нэг зуун арван нэгэн насныхаа найрыг элбэг дэлбэг хийнэ гэж зарлахад амтай бүхэн шаагилдаж, амьтай бүхэн шуугилдав.

Бильбо гэгээн цагаан өдрөөр гэв гэнэт алга болоод гэв гэнэтхэн гараад ирэхдээ амаараа зуу дахин хэтрүүлсэн ч гэсэн асар их олз омогтой ирснээс хойш нэгэн жарны туршид энгүй их эд баялаг, найгүй үрлэгэн зангаараа зард гарсан нэгэн билээ. Зөвхөн хамгийн мэргэн өтгөс л Уутан Хясааны доогуур үй олон суваг ухаастай, суваг бүхэн эрдэнэсээр чихээстэй гэсэн ярианд эргэлздэг байсан юм. Эд, эрдэнэсээр баян л юм биз гэж бодоход эрүүл мэнд нь ямар гэж санана! Хичнээн ч ус урсаад өнгөрсөн байхад ноён Торбинс ерэн насны сүүдэр зооглочихоод тавин настай юм шиг л гялалзана. Ерэн ес хүрчихээд байхад нь “Мөн ч сайхан толиотой байна” гэгцгээдэг байсан ч уул нь “Огт хэвээрээ байна” гэж хэлэх ёстой байлаа. Олон хүн толгой сэгсэрч “Энэ ч арай дэндэнэ ээ, тэр ч байтугай шударга биш байна, зарим нь яахаараа ийм азтай байдаг юм бэ, үхэх нь бүү хэл өтөлдөг ч үгүй, мөнгөн дотор хөрвөөж байх юм даа” гэнэ.

- Энэ ч сайны ёр биш дээ, нэг л юм болно шүү гэгцгээнэ.

Гэвч гай зовлон хараахан болоогүй, ноён Торбинсын эд баялаг, элдэв явдлыг их бага ямар нэг хэмжээгээр уучилцгааж байсан тул түүний алга тэнэгэр хэвээрээ байлаа. Тэр төрөл садныхантайгаа харилцаа сайтай (мэдээж Зуудаг Торбинсынхноос бусадтай нь) тэгээд ч олон ядуу хоббитууд зүгээр л түүнийг хайрлаж хүндэтгэдэг байв. Гэхдээ ноён Торбинс өөрөө ач гуч нараа өстөл хэнтэй ч ойр дотно нөхөрлөж байсангүй.

Тэдний дотроос хамгийн ахмад нь бөгөөд Бильбогийн хамгийн хайртай нь эцгийн талаас бүл ах, эхийн талаас төрсөн эгчийнх нь хүү, багадаа өнчирсэн Фродо Торбинс байлаа. Бильбо ерэн естэйдээ түүнийг өөрийн өв залгамжлагч болгосон тул Зуудаг Торбинсынхон юу ч үгүй хоцорсон юм. Бильбо, Фродо хоёр нэг өдөр буюу есдүгээр сарын 22-нд төрсөн ажээ.

“Манайд ирж амьдар даа хүү минь, тэгэхгүй бол насны ой юу ч биш болох нь байна” гэж Бильбо нэгэнтээ хэлэхэд Фродо тэднийд нүүж иржээ. Тэр үед Фродо хоббитуудын хэлдгээр бага насандаа буюу гал усанд гараа дүрэхэд бэлэн хорин хоёроос гучин гурван насны хоорондох гал халуун үедээ байлаа.

Тэр цагаас хойш Торбинсынхон арван нэгэн төрсөн өдрөө хөгжөөн баяр төгөлдөр тэмдэглэсэн боловч арван хоёр дахь нь ямар нэг үзэгдэж дуулдаагүй онцгой юм болох нь яах аргагүй илэрхий байлаа. Бильбо зуун арван нэгэн нас хүрсэн нь гурван нэгийн тоо учраас яаж ч бодсон үнэхээр гойд хүндлүүштэй нас (домогт Хөгшин Крол хүртэл нэг зуун гуч насалсан шүү дээ), Фродо гучин гурав хүрч байгаа нь хоёр гурвын тоо учир бас л онцгой тохиолдол. Хоббит гучин дөрөв хүрээд насанд хүрсэнд тооцогддог. Хойд отго болон Голын хөндийнхөн цөм хэл амаа билүүдэж, болох гэж буй үйл явдлын сураг Хоббитан даяар тарлаа. Хаа сайгүй л Бильбогийн долоон булчирхайг тоочиж, түүний паянг дэлгэж, ахмад настай

хоббитуудын дурсамж яриа гэнэтхэн сонирхолтой болж, тэд ой дуртгалаа ихэмсгээр ухаж төнхөх болов.

Амаа ангайгаад сонстол ярьдаг хүн бол Жихар хочит хөгшин Сэм Скромб байлаа. Голын хөндий орох замын хажууд орших “Даруухан булан” уушны мухлагт цугларагсад түүний яриаг сонсч суув. Тэр Уутан хясаанд дөч гаран жил цэцэрлэгч хийсэн, тэрнээс өмнө хөгшин Норны аж ахуйд тусалдаг байсан учир их мэдэмхий ярьж байв. Одоо тэр хөгширч, хөдөлгөөн удаан болсон ба бараг бүх ажлыг нь бага хүү Сэм Скромби хийдэг болсон. Эцэг, хүү хоёр хоёулаа Бильбо, Фродо хоёртой сайн харилцаатай, Хясаан дээр тэдний эдлэнгийн доохно, Уутын гурав дахь байшинд суудаг билээ.

- Ноён Бильбогийн тухай юу ч гэж ярилаа гэсэн тэр бол дээд зэргийн хоббит, их ч эелдэг найрсаг хүн гэж Жихар хэлэв. Тэр худлаа хэлсэнгүй.

Бильбо түүнтэй машид найрсаг харилцдаг, “хүндэт Хэмбриж” гэж дууддаг, жил бүр хүнсний ногооны зөвлөгөөнд урьдаг байлаа. Арга ч үгүй юм, “үндэс үр”, тэр дундаа төмсний талаар Жихар тойрогтоо хамгийн их мэдлэгтэй нь юм чинь. (Тийм л юм чинь тэгэлгүй яахав гэж өөрөө хэлдэг).

- Бильбогоос гадна тэр нүхэнд Фродо билүү хэн ч билээ дээ нэг юм байдаг байх аа? – гэж Голын хөндийн хөгшин Бороохой асуугаад – Тэр Торбинс овогтой боловч үнэндээ бол тал нь Брендизайк юм шүү дээ, тэгж л ярьцгаадаг юм. Хойд отгын Торбинс яахаараа өөр цусны Забрэндээс эхнэр авсны учрыг би бодоод олдоггүй юм гэв.

- Тэр өөрөө манай цусных биш шүү дээ, тэд чинь Брендидуимын гэж Жихарын хөрш Хоёр Амт ярианд оролцов – тэд Брендидуимын хамгийн хэрэггүй газарт суудаг, бүр Мөнхийн ой руу шургаад орчихсон юм чинь. Мөн газраа олов оо.

- Зөв юм ярьж байна ах минь, ерөнхийдөө Туулай толгодын дэлдэнгүүд Мөнхийн ой руу ёстой шургаагүй, гэхдээ тэд тун хачин амьтад гэж та үнэн хэллээ. Яахаараа дандаа голын тэг дунд хөвж явдаг юм бэ, муу юм болоход тун ойрхон, харж л байгаарай. Тэхдээ л ноён Фродо эрээд олдохгүй хоббит доо. Ноён Бильбог өвчсөн юм шиг адилхан, гэхдээ хэн хэнтэйгээ адилхан байх нь ямар хамаа байх вэ: эцэг нь ч бас Торбинс шүү дээ. Ер нь ноён Үнэт Торбинс жинхэнэ зөв хоббит байсан даа, живж үхсэн л болохоос ярих юм байхгүй гэж Жихар хэлэв.

- Живсэн гэнэ ээ гэж сонсогчдын зарим нь гайхав. Тэд энэ тухай, бас өөр олон юмны тухай сонссон боловч айл амьтны хов живийг ихэд сонирхдог тул хэд ч дахин сонсоход бэлэн байдаг билээ.

- Тэгсэн л гэж ярьдаг юм шүү дээ, ноён Үнэт чинь хөөрхий Гэнэн дэлдэнг эхнэр болгож авсан юм. Тэр чинь эхийн талаасаа ноён Бильбогийн яах аргагүй бүл дүү байсан юм (эх нь тэр үеийн манай Молтогчин ноёны бага охин байсан юм), ноён Үнэт чинь өөрөө бүл дүү нь байсан юм. Тэгэхээр ноён Фродо эхийнхээ ч, эцгийнхээ ч талаас ноён Бильбогийн хамгийн ойрын цусан төрөл мөн болж таарч байгаа биз дээ. Ноён Үнэт тэр үеийн захирагч Бөгтөр Дэлдэнгийн алба хаадаг байсан, ээ базарваань мөн ч их хоолонцор захирагч байж билээ, тэгээд л нэг өдөр хавтгай завиар гол гатлах гэж яваад эхнэртэйгээ живчихсэн, тэгээд л

хөөрхий Фродо нялхаараа өнчин хоцорсон, тийм л юм болсон юм даа хөөрхий.

- Тэр хоёр чинь баахан идэж аваад сарны гэрэлд голоор зугаалж явсан, Үнэт их идсэн учир хүнд болоод завиа хөмөрчихсэн гэж би сонссон юм байна гэж хөгшин Бороохой хэлэв.

- Эхнэр нь нөхрөө түлхчихсэн, нөхөр нь эхнэрээ татаж унагасан гэж би сонссон юм байна гэж тээрэмчин Дорги хэлэв.

- Дорги чи, сонссон болгоноо үнэн гэж худал бүү ярь, түлхсэн, живсэн ч гэх шиг... Ишш, хэлнийхээ загатнааг гаргаж гэнэ. Тэр муу хавтгай завь шиг юм чинь өөрөө аяндаа хөмөрнө, түлхэж мүлхэх хэрэггүй гэж тээрэмчинг үзэж чаддаггүй Жихар хэлэв.

- Нэг үгээр хэлэхэд Фродо тэгээд л тэднийхний ярьдгаар газар дээр гадас шиг ганцаараа үлдсэн хэрэг. Эргэн тойронд нь дан молтогчингууд, молтогчингийн үүр л гэсэн үг. Хөгшин Бөгтөрийн төрөл садангууд гэхэд л лав хоёр зуу гарна. Харин Лякошел Торбинсынхон бол мэдээж заяагүй амьтад. Бильбо гномуудтай яваад сураггүй алга болоход Уутын өвийг нь идэх гэж л ирсэн хэрэг. Гэтэл тэр эргээд ирсэн, тэднийг хөөж явуулаад амар сайхан амьдарсан, өтөлж хөгширнө ч гэж байдаггүй, өвдөж зовно ч гэж байдаггүй. Дээрээс нь бас өвийг нь идэх хүн гараад ирсэн, бүх баримт бичиг нь бүрэн болсон байгаа, итгэж болно. Лякошелийнхэн чихээ харж чадахгүйн адил Уутыг идэж чадахгүй, тэгж байж чихээ харчих вий дээ зайлууул.

- Тэнд замбараагүй их мөнгө булчихсан гэдэг биз дээ, танай тэр Хясааны доогуур нэлд нь хөндийлж ухсан, хонгил бүхэн алт, мөнгө, эрдэнэстэй авдруудаар дүүрэн байдаг гэж ярьцгаадаг - гэж Газарухаас Баруун тойрог руу явж байгаа замын эр хэлэв.

- Чи ярьснаасаа ихийг сонссон байна, юуны чинь алт эрдэнэс вэ? ноён Бильбо мөнгө хайрладаггүй, мөнгөөр дутдаг ч үгүй байх, газар доогуур хонгил ухсан хүн байхгүй. Жараад жилийн өмнө, намайг борвиндоо баастай байхад ноён Бильбо эргэж ирснийг санаж байна. Би дөнгөж л Норн өвгөнийд /талиийгаач эцгийнх нь үеэл дүү байсан юм/ юухан хээхэн хийдэг байсан, эдлэн газраа худалдаж байсан болохоор хэрэгт дуртай юмнуудыг хөөхөд нь тусалдаг байсан. Яг тэр үед ноён Бильбо гэгээн цагаан өдөр гэв гэнэт хүрээд ирсэн, том том шуудай, хоёр ч авдар ачсан одой морь хөтлөөд ирсэн. Тэр ачаа нь мэдээж хэрэг, эргэн тойрон алтан уул байдаг харийн орны эрдэнэс байж таарна. Гэвч газар ухаж яах юм бэ? Багтаах зайгүй юм биш. Манай Сэмээс асуусан ч болно, тэнд юу болсныг бүгдийг мэддэг юм. Ноён Бильбо өнгөрсөн амьдралаа ярина, манай тэнэг сонсоно. Ноён Бильбо бүр бичиг зааж өгсөн, муу санаагүй нь мэдээж, бичиг сурлаа гээд юу нь муу байх вэ дээ.

“Юуны чинь эльфүүд, луунууд. Тэрний оронд чи төмс, байцаа ярь. Тэгээд ч бусдын хэрэгт хамраа бүү дүр, хамаргүй болж хоцров” гэж би хүүд хэлдэг юм. Тэгж л хэлсэн юм, сонсоогүй хүн байвал дахиад ярьсан ч болно – гэж Жихар хэлээд тээрэмчин, замын хүн хоёр руу харц чулуудав.

Гэвч сонсогчид ярьснаасаа буцсангүй. Бильбогийн эрдэнэсийн тухай явган ярианд залуучууд дэндүү дассан байлаа.

- Тэр хичнээн ч эрдэнэс авчирсан байлаа гэсэн дараа нь булсан байж таарна, гэртээ сууна гэж

байхгүй, хаана л бол хаана явж байдаг – гэж өөрийг нь дэмжих хүн байгааг мэдэрсэн тээрэмчин эсэргүүцээд – Харь холын хичнээн зочид тэднийд ирдэг билээ. Шөнийн цагаар гномууд ирнэ, тэр муу илбэчин Гэндальф байна. Үгүй ээ Жихар, чи юу ч ярьсан хамаагүй, тэднийх тун эвгүй газар даа. Уутынхан угаасаа их будлиантай улс гэв.

- Дорги чи учрыг нь олохгүй юмаа ярихгүй байсан нь дээр байлгүй – гэж Жихар урьдахаасаа ч их таалагдахгүй байгаа тээрэмчинд дахин зөвлөөд-бүгдээрээ тийм будлиантай байсан болоосой, нүхийг нь алтдаад өгсөн ч нөхөртөө гүрүүшиг пиав тавьдаггүй амьтныг би бас мэднэ. Харин Уутынхан бол юмыг зөв ойлгодог улс. Дайллагад нэг ч хүн үлдээхгүй урина, бүгдэд нь бэлэг тараана, тэхдээ хэзээ нэг цагт биш, яг энэ сард гэж манай Сэм хэлсэн.

Хоёр хоногийн дараа нарлаг сайхан есдүгээр сарын дундуур дайллагаар галын наадам болно гэсэн яриа (мөнөөх бүхнийг мэддэг Сэм л тараасан бололтой) тарав. Хоббитан оронд Хөгшин Молтогчин нас барснаас хойш лав зуун жил галын наадам болоогүй ажээ. Товлосон өдөр ойртож байх үеэр нэг орой үзэгдээгүй хачин хайрцагнууд ачсан маш гоё морин тэрэг Норгордоор түжигнэн давхиж, Уутан Хясаанд зогсов. Хоббитууд үүд хаалгаараа шагайж, харуй бүрий гудамж руу харцгаана. Тэрэгний морьдыг урт сахалтай, юүдэнгээ буулгасан гномууд залж, үл ойлгогдох дуу аялна. Зарим нь буцаж яваад, зарим нь Уутанд үлдлээ. Есдүгээр сарын хоёр дахь долоо хоногийн эцсээр гэгээн цагаан өдөр Брендидумын гүүрний талаас нэг морин тэрэг орж ирэхэд тэргэн дээр нэг өвгөн суусан байв. өвгөн цэнхэр өнгийн шовгор оройтой малгай, бараг өсгийдөө хүрсэн урт саарал цув өмсч, мөнгөлөг ороолт зүүжээ. Урт цагаан сахлаа сайтар янзалсан нь илт, сүртэй саглагар хөмсөг нь малгай дороос цухуйжээ.

Хүүхдүүд суурины гудамжаар Хясаа хүртэл тэргийг даган гүйлдэв. Тэргэн дээр пуужингууд ачсан байгааг хүүхдүүд дор нь ойлгов. Өвгөн Бильбогийн үүдэнд хүрээд хоббит болон эльф үсгээр “Г” гэсэн улаан тэмдэгтэй янз бүрийн том пуужингууд буулгав.

Тэр тэмдэг нь мэдээж Гэндальфын тэмдэг, өвгөн өөрөө янз бүрийн өнгийн гал, утаа хийх талаар Хоббитан даяар алдартай агуу шидтэн Гэндальф байлаа. Түүний жинхэнэ ажил хэрэг гал угаанаас хамаагүй аюултай, хүнд хэцүү боловч хоббитууд тэр талаар юу ч мэдэхгүй тул тэдний хувьд Гэндальф зүгээр л найрын чимэг байв. Тиймээс л хүүхдүүд түүний араас гүйлджээ.

“Гэндальф ирж байна, аянга нижигнэнэ” гэж хүүхдүүд хашгиралдахад өвгөн инээмсэглэж байв. Тэр Хоббитанд хааяа нэг сэмхэн ирдэг боловч хараад л таньцгаадаг, түүний аянгат галын наадмыг одоо зөвхөн эртний хөгшид л санаж байлаа.

Өвгөн Бильбо болон гномуудын хамтаар ачаагаа буулгаж дуусахад хүүхдүүдэд хэдэн зоос тараасан боловч өнөөх тэсэлж тоглох хөгжилтэй сонин тоглоом өгөөгүй тул тэд их л гонсгор байцгаав.

- Гэртээ харьцгаа, цагаа болохоор хэн бүхэнд хангалттай хүрэлцэнэ гэж өвгөн хэлээд Бильбогийн араас орж хаалгаа түгжжээ.

Хүүхдүүд жаахан хүлээж байгаад тарцгаав. “Тэр найр нь тэгээд хэзээ юм бол доо” гэж тэд

бодоцгоов.

Гэндальф, Бильбо хоёр нээлттэй цонхны дэргэд зогсоод цэцэглэж буй баруун цэцэрлэг рүү харж байлаа. Нар жаргах дөхөж, хурц, тунгалаг гэрэл нь цэцэрлэгийг тод гийгүүлж байв. Хүрэн улаан арслангийн ам, алтлаг наранцэцэг, гал шаргал алтаргана цэцэгс байшингийн дугариг цонхонд тултал ургажээ.

- Чиний цэцэрлэг ч гоё юм аа гэж Гэндальф хэлэв.

- Тийм шүү гэж Бильбо зөвшөөрөөд – Хоббитан бол сайхан ч газар, гоё ч цэцэрлэг, гэвч би ядарч байна, амрах цаг ирлээ гэв.

- Тэгэхлээр чи хэлснээрээ хийх гэж байна уу?

- Мэдээж, би хэлсэн үгээсээ хэзээ ч буцаж байгаагүй.

- За тэгвэл яриад байх ч юм алга. Шийдсэн л бол шийдсэн, бодсоноороо хий, чамд сайн юм болно, магадгүй ганц чамд ч биш байх.

- Цаг нь болохоор харъя даа.

Хясаанд ачаатай тэрэгнүүд ар араасаа ирсээр байв. Зарим хүн “Гадныхан л олз олж байна, гэтэл нутгийн мастерууд хийх юмгүй сууж байна” гэж үглэж байсан боловч төдөлгүй Уутан хясаанаас янз бүрийн амтат хоол, умдаа, Норгорд болон Хоббитан даяар худалддаг тансаг чамин юм бүхний захиалга дарав. Найр өнөө маргаашгүй болох нь, гэтэл урилга барьсан шуудан зөөгч яагаад алга байдаг билээ” гэж хүмүүс гайхаж байв.

Урилга ч удаж төдсөнгүй, шуудан зөөгчид хүрэлцээгүй учир сайн дурынхныг ажиллуулахад хүрэв. Бильбо руу эелдэг бөгөөд уран үгтэй талархал зуу зуугаараа урслаа. “Баярлалаа, заавал очно” гэсэн үгийг янз янзаар хэлж байв.

Уутын хэрмийн хаалган дээр “ЗөВХӨН НАЙРЫН ХЭРГЭЭР ОРНО” гэсэн бичиг хаджээ. Гэвч найрын хэргээр ч орох боломжгүй байв. Бильбо амсхийх ч завгүй, урилга бичиж, хариулт үдэж, бэлэг боож, хажуугаар нь найртай ямар ч хамаагүй өөрийн ажлаа амжуулж байлаа. Гэндальф ирснээс хойш тэр хэнд ч харагдсангүй.

Нэг өглөө хоббитууд Уутын хэрмийн гол хаалганы өмнө асар майхнууд босгож, сүүдрэвчүүд барьж байхыг харав. Төв замын талаас өтгөн бутан шугуй дундуур зам гарган том цагаан хаалга босгов. Нугатай залгаа эдлэн бүхий Уутынхнаас гаралтай гурван бага овгийнхон гайхан биширсэндээ дуу алдаж, нийтээрээ агаархалд автав.

Асар майхнууд өдрөөр биш цагаар олширч байлаа. Хамгийн том асарт зассан урт ширээний толгой талд аварга том модыг ургаагаар нь үлдээжээ. Модны мөчрүүдэд дэнлүү өлгөжээ. Хоббитуудад хамгийн сонирхолтой зүйл нь нугад задгай газар зассан гал тогооны газар байв. Эргэн тойронд өчнөөн олон хоолны газарт найрын зоогийг бэлтгэж байсан бөгөөд Уутын өргөөний дэргэд гномууд болон бусад шинээр ирэгсэд нэмж энэ аварга гал тогооны газрыг

зассан нь хоббитуудыг бүр ч догдлуулав.

Энэ хооронд тэнгэр эвгүйрч, найрын өмнөх лхагва гаригт цаг агаар муудлаа. Хүн бүр л сэтгэл түгшиж эхлэв. Гэвч хүн бүрийн хүсэн хүлээсэн есдүгээр сарын хорин хоёрны пүрэв гариг болоход үүлс сарниж, нар мандан туг дарцгууд дэрвэж, найр наадам эхлэх нь тэр.

Бильбо Торбинс зүгээр л найр хийнэ гэсэн боловч үнэн хэрэгтээ агуу том баяр наадам үүсгэв. Ойрын хөршүүдээ нэгийг ч үлдээлгүй урьсан бөгөөд зарим нэгийг нь урихаа мартсан ч өөрсдөө хүрээд ирэв. Хоббитаны алсын тойргуудаас олон хүн уригдсан ба хилийн чанадаас ч зочид иржээ. Бильбо урилгатай ба урилгагүй зочдоо цагаан хаалган дээр угтав. Тэр хүн бүрт бэлэг өгсөн ба дахиж бэлэг авах гэсэн зарим нь арын хаалгаар гараад дахин цагаан хаалган дээр ирж байлаа. Хоббитууд төрсөн өдрөөрөө бусдад бэлэг өгдөг бөгөөд тэр нь голдуу үнэ хямд тэгээд ч заавал хүн бүрт өгдөггүй байв. Гэхдээ л энэ бол сайхан заншил байсан юм. Норгорд болон Голын хөндийд төрсөн өдрийн баяргүй өдөр нэг ч үгүй тул энэ нутгийн хоббитууд наанадаж долоо хоногт нэг бэлэг авах найдвар бүрэн байлаа. Бэлэгнээс уйдна ч гэж үгүй.

Гэтэл энэ удаагийн бэлэгнүүд үнэхээр гайхамшигтай байв. Залуухан хоббитууд бэлгээ биширсэндээ болоод арай л идэж уухаа мартчихсангүй. Тэдэнд ер бусын гайхалтай тоглоомууд бэлэглэсэн ба заримд нь бүр шидэт тоглоом ч таарчээ. Зарим тоглоомыг жилийн дотор, заримыг нь бүр жилийн өмнө захиалсан ба гномууд маш их хичээн зүтгэж Харголын болон Бэлийн хаант улсаас авчирсан ажээ.

Зочин бүрийг угтан авч мэндчилээд гол хаалгаар оруулсны дараа дуу, хөгжим, бүжиг, тоглоом эхлэв. Хоол унд хэрээс хэтэрсэн элбэг дэлбэг. Бага үдийн, үдийн, оройн гэж гурван удаа зоог барьсан ба бага үдийн зоогийн өмнө зочид асруудад орж, үлдсэн бүх цагийг идэж ууж өнгөрөөв. Дуртай асартаа орж, арван нэгэн цагаас зургаа хагас хүртэл буюу галын наадам эхэлтэл наргив.

Галын наадмыг Гэндалф зохион байгуулсан ба тэр пуужин авчирсан төдийгүй, тэнгэрийг галт зургаар чимэхийн тулд заримыг нь өөрөө хийжээ. Тэрбээр үй олон цаасан буу, бенгалийн гал, алтан цацраг, бамбар бадраагч, гномын цахилагч гэрэл, эльфийн цахилгаан, гоблины аянга урлажээ. Түүний бүтээл дэндүү гарамгай болдог бөгөөд жилээс жилд төгс боловсорч байв.

Эхлээд галт шувууд тэнгэрт халин нисэхдээ чангаар жиргэн дуулна. Утаан модны бараан мөчрүүд дээр хаврын тод ногоон навчис гялсхийн дэлгэрч, гэрэлт мөчрүүдээс хоббитуудын толгой дээр гал цэцгүүд асгаран буух ба нүдний өмнө ирээд унтрахдаа агаарт ялдам сайхан үнэр үлдээнэ. Нүд гялбам хурц өнгөт эрвээхэйнүүд моддыг бүрхсэнээ өнгө өнгийн гал болон тэнгэрт дүүлж, тэгснээ бүргэд, дарвуулт онгоц, хунгийн сүрэг болж хувирна. Хүрэн улаан үүлс тэнгэрт хурснаа гялалзсан бороо болж газарт бууна. Дараа нь дайчин уриа цуурайтаж, мөнгөлөг өнгөт жаднууд тэнгэрт дүүлээд могойн исгэрээ мэт чимээ гарган гол руу сүнгэнэн орно.

Дараа нь Гэндалф Бильбод зориулсан гол үзүүлбрээрээ өөрийнхөө хэн болохыг харууллаа. Гал гэрэл бүгд унтрахад тэнгэр өөд аварга том утаан багана сүмбэрлэснээ алсын уулын оройд

бөөгнөрөхөд уулын оргил шатаж, улаан-ногоон дөл болон дүрэлзэв. Дөлөн дотроос алтлаг улаан өнгөт луу дүүлэн гарч ирлээ. Яг жинхэнэ амьд луу шиг аймшигтай нүд нь хилэнгээр дүрэлзэж, амнаасаа галаар тургин, аймшигтайгаар хүрхэрч, зочдын дээгүүр гурвантаа эргээд яг дээрээс нь буух шиг болов. Бүгд газарт нам унав. Луу тэдний дээгүүр нисэн өнгөрч агаарт нэг эргэснээ голын хөндий дээр чих дөжрөм их чимээтэй дэлбэрэв.

- Ширээнд морилогтун – гэх Бильбогийн дуу сонсдов.

Нийтийг хамарсан айдас, сандраан арчсан мэт алга болж, зочид үсрэн босоцгоов. Ер бусын тансаг найр эхэлж, өндөр мод бүхий том асарт хамаатан саднуудад зориулан онцгой ширээ засчээ. Тэнд нэгзуун дөчиндөрвөн зочин хурсан (хоббитууд энэ тоог “хотол” гэдэг) бөгөөд тэд бол Бильбо, Фродо хоёртой садан төрлийн ямар нэг холбоотой хүмүүс, дээр нь Гэндальф зэрэг цөөн тооны сонгомол найзууд нь байв.

Тэдний дунд эх эцгийнхээ зөвшөөрлөөр ирсэн өсвөр насны хоббитууд олон байлаа. Эх, эцгүүд тэднийгээ айлын хоолны ширээнд оройтгол суухыг зөвшөөрдөг нь тэднийг цадтал идүүлэх байтугай зүгээр хооллох ч бэрх байдагтай холбоотой.

Тэнд маш олон Уутынхан, Талхныхан, Молтогчингийнхон, Дэндүүдэлдийнхэн цугларсан ба Ухагчийнхан (Бильбогийн эмээгийн садангууд), Идэгчийнхэн, Уугчийнханыг (өвгийнх нь садангууд) ч орхисонгүй, Гүн ухагчтийнхан, Минжийнхэн, Их Гэдэстийнхэн, Доргынхон, өндрийнхөн, Үст Тавхайнхан хүртэл иржээ. Зарим нь гэв гэнэтхэн Бильбогийн хамаатан садан болсон, зарим нь Норгордод хэзээ ч байгаагүй хүмүүс байв. Тэр ч байтугай Оддо Лякошел-Уут эхнэр Любелиятайгаа хамт сууж байлаа. Тэр хоёр Бильбо, Фродо хоёрыг тэвчиж чаддаггүй байсан боловч найрын урилгыг гантиг хуудсан дээр алтан бэхээр бичсэн байсан тул тэсч чадсангүй ажгуу. Тэгээд ч тэдний бүл ах Бильбо сайхан хоолтойгоороо эртнээс цуугтай билээ.

Нэг зуун дөчин дөрвөн сонгомол зочин урьд өмнө ууж идэж үзээгүй тансаг унд хоолоор ханаагүйгээ ханаж цадаагүйгээ цадтал дайлуулна гэж мэдэж байсан боловч зоогийн дараа эзний хэлэх үгнээс эмээсхийж байлаа. Одоо яая гэхэв, эзэн хэлэхгүй байж болохгүй, зочин сонсохгүй байж болохгүйгээс хойш. “Шүлэг” нэртэй шал дэмий юм урсгах юм уу, аяга юм татчихаад хэнд ч ойлгомжгүй тэнэг аяллынхаа тухай чалчиж эхэлнэ дээ. Зочид амаараа гартал идэцгээв. Цадсан дээрээ цадтал, хэрээсээ хэтэртэл, амттанд тамшаалан байж, удтал идэцгээв. Юу идээгүй, юу гэр рүүгээ авч яваагүй гэхэв. Дараа нь тэр хавийнхан долоо хоногийн турш идэх юм худалдаж авсангүй, гэвч худалдаачид хохирсонгүй, тэртэй тэргүй Бильбо тэдний хамаг агуулахыг хоосолж, хамаг нөөцийг нь барсан юм чинь. Мэдээж мөнгөөр.

Эцэст нь идэгчдийн эрүү чилж, арай ядан хөдлөх үеэр үг хэлэх цаг боллоо. Зочид хоббитуудын хэлдэгээр “жаахан юм идсэн” тул сэтгэл өндөр байлаа. Хундаганд дуртай ундаа нь байна, тавгануудад дуртай хоол амттанууд нь байна... тэгэхээр тэр яривал ярьж л байг, сонсоод л, алгаа ташаад л сууж байя. Бильбо босч:

- Эрхэм хүндэт ураг төрлүүд минь – гэж үгээ эхлэв.

- Чимээгүй, чимээгүй, чимээгүй гэж зочид ам амандаа хашгиралдав. Чимээгүй байхыг нэгэн дуугаар уриалсан дуу улам чангарч, яагаад ч чимээгүй болохгүй шинжтэй болов.

Бильбо ширээнээс холдож, дэнлүүнүүд зүүсэн том модны дэргэд очоод сандал дээр гарав. Түүний баяр ёслолын жавхаатай нүүрэн дээгүүр өнгө өнгийн туяа цацарч, торгон хантаазных нь алтан товчнууд гялалзана. Тэр хэн бүхний нүдэнд бүрэн ил, нэг гараа халаасандаа хийж нөгөө гараараа толгой дээгүүрээ даллана.

- Эрхэм хүндэт Уутынхан, Талхныхан, Молтогчингийнхон, Дэндүүдэлдийнхэн Ухагчийнхан, Идэгчийнхэн, Уугчийнхан, Гүн Ухагчийнхан, Минжийнхэн, Их Гэдэстийнхэн, Доргынхон, өндрийнхон, Үст Тавхайнхан минь ээ!

- Бас Үст Тавхайнхан – ширээний доод булангаас нэгэн хижээл эрхэм хашгирав. Тэр мэдээж Үст Тавхай мөн бөгөөд үсэрхэг том тавхайгаа ширээн дээр тавьжээ.

- Бас Үст Тавхайнхан – гэж Бильбо зөвшөөрөөд – энхрий эрхэм Лякошель –Уутынхан минь ээ, би та нартайгаа Уутан Хясаан дээр мэндчилж байгаадаа их баяртай байна. өнөөдөр би нэг зуун арван нэгэн нас хүрлээ, гурван нэг гэж хэлж болно.!

- Урраа, урраа, урраа, түм насалтугай хэмээн зочид хашгиралдаж, ширээгээ бөмбөрдөн балбацгаав. Мэдээж товч бөгөөд тодорхой.

- Та нарт ч гэсэн миний адил хөгжилтэй байгаа гэдэгт найдаж байна.

Чих дөжрөм алга ташилт нижигнэв. “Тэгэлгүй дээ”, “өөр яах юм бэ”, “Мэдээж” хэмээн зочид орилж, элдвийн бүрээ хангинаж, бөмбөр нижигнэв.

Өсвөрийн хоббитууд ЧРНРЧ гэсэн хачин шошготой олон зуун аялгуут цаасан буунуудаа задлав. Яагаад ийм шошготой байгааг тэд ойлгоогүй боловч үнэхээр гоё цаасан буунууд байв. Цаасан буун дотор гайхалтай гоё, чанга дуутай зэмсгүүд байлаа. Асрын нэг буланд өсвөрийн молтогчин, дэндүүдэлдүүд Бильбо ах үгээ хэлээд дууслаа гэж бодоод найрал хөгжим эгшиглүүлж, бүжиглэж гарав. Ихбаяр Молтогчин хөвгүүн, Хөөрхөн Ам, Дэндүүдэлд охин хоёр ширээн дээр гараад гартаа шаржигнуур хонх жингэнүүлэн “Навсага-савсага” гэдэг их аятайхан боловч арай л ширүүхэн бүжгийг ёстой үзүүлээд өгөв.

Гэвч Бильбо анхааралтай сонсохыг шаардаж, нэг бандийн барьж байсан том бүрээг булааж аваад гурвантаа бүрээдэхэд чимээ шуугиан намжлаа.

- Би та нарыг удаан саатуулахгүй – гэж Бильбо хашгирахад бүгдээрээ алга ташив.

- Би та нарыг өнөөдөр нэг онцгой зорилготой цуглуулсан юм гэж нэг л учиртай хэлэхэд нь бүгд болгоомжилж эхлэв.

- Нэг ч гэж дээ, гурван онцгой зорилгоор гэж хэлэхэд бараг нам жим болж, зарим Молтогчин сонсоход бэлтгэв.

- Нэгдүгээрт, би та нарыг бүгдийг чинь харж байгаадаа жаргалтай байгаагаа, та нар шиг

гайхамшигтай сайхан хоббитуудтай нэг зуун арван нэгэн жил амьдрах хөнгөнөөс хөнгөхөн гэж хэлэх гэсэн юм.

Сайшаан дэмжсэн яриа дүнгэнэлдэв.

- Та нарын сайн талыг би мэдэх ёстойгоосоо хоёр дахин муу мэднэ, муу талыг би хайрлах ёстойгоосоо хоёр дахин бага хайрладаг.

Хүчтэй хэлсэн боловч тийм ч ойлгомжтой биш хэлсэн тул цөөхөн алга ташилт сонсдож, бүгдээрээ “ийм үг сонсоод баярлах ёстой юу” гэж эргэлзэв.

- Хоёрдугаарт, та нарыг насныхаа ойгоор баярлуулах гэж...

Урьдын адил сайшаан дэмжсэн яриа дүнгэнэлдэв.

- Үгүй юм аа, миний биш, бид хоёрын ойгоор. Учир нь энэ өдөр надаас гадна миний үеэл дүү, миний өв залгамжлагч Фродо төрснийг та нар мэдэж байгаа. Өнөөдөр тэр эрийн цээнд хүрч, өмч хөрөнгийн эзэн болж байна.

Ахмадуудаас ганц нэгхэн хүн үл ойшоох байдалтай алга ташмар болж, залуучууд “Фродо, Фродо, Фродо найз минь,” гэж хашгиралдав. Лякошелүүд уруу царайлж, Фродо “өмч хөрөнгийн эзэн болно гэдэг нь юу гэсэн үг юм бол” гэж таахыг оролдов.

- Бид хоёр нийлээд нэг зуун дөчин дөрөв хүрч байна. Яг энд хуран цугларсан та нартай буюу нэг сүрэгтэй тэнцүү, оновчгүй үг сонгосонд уучлаарай.

Зочид таг дуугүй. Энэ чинь бас юу гэсэн үг вэ? Олон зочин, ялангуяа Лякошелүүд биднийг зөвхөн тоо гүйцээх гэж урьсан юм байна гэж ойлгоод, доромжиллоо хэмээн уурлацгаав. “Мөн ярив аа, нэг сүрэг гэнэ шүү, түй ямар бүдүүлэг юм бэ”.

- Тэгээд ч өнөөдөр бол би Урт нуурын дэргэдэх Эсгаротод торх зайдалж хүрсний ой байгаа юм. Тэр үед би төрсөн өдрөө гэж мэдээгүй л дээ. Би дөнгөж тавиннэгэн нас хүрч байсан, залуу байхад нэг нас нэмэгдэх гэж юу байдаг билээ дээ. Тэгэхдээ сайхан найр хийсээн, харин би л даарснаас сүрхий ханиад хүрч арай гэж л “мадидадаа” гэж хэлсэн. Одоо би энэ завшааныг ашиглан тэр үгээ зохих ёсоор хэлье. Миний даруухан баярт хүрэлцэн ирсэнд тань та бүхэнд маш их талархлаа.

Хэн ч дуугарсангүй. “Одоо энэ дуу дуулна, эсвэл шүлэг уншина” гэж айгаад бүгд урьдчилан уйдаж эхлэв. Өөрөөр энэ найраа яаж төгсгөх вэ дээ. Гэтэл бид энэний эрүүл мэндийн төлөө уумаар байдаг гэж бодоцгоов. Гэтэл Бильбо дуулсан ч үгүй, шүлэг ч уншсангүй. Тэр эрт амьсгаа аваад:

- Гуравдугаарт буюу эцэст нь нэг ЗАРЛАЛ байна – гэж маш чанга хэлэхэд боломжтой байгаа хэн бүхэн нуруугаа эгцлэн сонсоцгоов.

- Хэдийгээр би түрүүн та нарын дэргэд нэг зуун арван нэгэн жил амьдрах хөнгөнөөс хөнгөхөн гэж хэлсэн боловч чиг хэрээ мэдэх цаг боллоо гэж гунигтайяа зарлах гэсэн юм. Би

явлаа. Нүдний чинь өмнө алга боллоо. Хагацацгаая.

Тэр сандал дээрээс буунгуут үзэгдэхгүй алга болов. Хурц гэрэл мэлсхийхэд бүх зочдын нүд гялбаж нүдээ аньсхийв. Нүдээ нээгээд харахад Бильбо оргүй алга болсон байлаа. Нэг зуун дөчин дөрвөн хоббит мэгдэн сандарч мэл гайхан хөдөлгөөнгүй сууна. Хөгшин Үст Тавхай хөлөө ширээн дээрээс буулгаж, дороо дэвсэлж эхлэв. Нам жим болж, зочид ухаан орж эхлэв. Тэгснээ гэнэт бүх Уутынхан, Талхныхан, Молтогчингийнхон, Дэндүүдэлдийнхэн, Ухагчийнхан, Идэгчийнхэн, Уугчийнхан, Гүн Ухагчийнхан, Минжийнхэн, Их Гэдэстийнхэн, Доргынхон, өндрийнхөн, Үст Тавхайнхан нэгэн зэрэг ярьж эхлэв.

Тэд “Энэ бол утга учиргүй балай юм, энд байгаа бүхнийг хурдхан ууж идэж дуусгах хэрэгтэй” гэгцгээлээ. “Энэ эрүүл ухаантай биш гэж би дандаа л хэлдэг байсан” гэж бүгдээрээ хэлцгээв. Юу болоод өнгөрснийг хэн ч ойлгосонгүй боловч бүгдээрээ л балай юм хийлээ гэж хараацгаана. Ганцхан мэргэн ухаант хөгшин Тэнэг Дэндүүдэлд л зальтайхнаар онийсхийж суулаа. өндөр нас ч, хэрээс хэтэрсэн их хоол унд ч түүнийг бүдүүрүүлсэнгүй учир тэр өөрийн бэр Намжтимаад:

- Ээ дээ энэ ч нэг л биш байна даа, тэнэмэл Бильбо дахиад л тэнээд явчих шиг боллоо. Зөнөг золиг чинь зүгээр сууж чадахгүй юм байна л дээ. Тэгээд юу гэж? Ширээн дээр хоол үлдсэн байна – гээд Фродог дуудаж дахиад дарс авчир гэв. Нэг ч үг хэлээгүй ганц хүн бол Фродо байлаа. Тэр Бильбогийн хоосон сандлын дэргэд хашгиралдаан, асуултуудыг үл анзааран дуугүй сууж байв. Тэр урьдаас мэдэж байсан боловч энэ үйлдлийг үнэлж цэгнэж суугаа нь мэдээж бөгөөд зочид нийтээрээ Бильбог буруушааж байгааг хараад инээдээ барьж ядан байв. Гэхдээ л түүнд нэг л гунигтай байв. Тэрбээр хөгшин хоббитыг үнэнээсээ хайрладаг болохоо гэнэт ойлгожээ. Зочид ууж идэж, Бильбогийн өнөөдрийн болоод урьд өмнөх тэнэг явдлуудыг шүүмжилсээр, уурлаж хилэгнэсэн Лякошелийнхэн л яваад өгчээ. Фродо найр даргалж залхсан тул дарс нэмж өгөхийг тушаагаад суудлаасаа босч, Бильбогийн эрүүл мэндийн төлөө нэг хундага хоосолчихоод асраас сэмхэн гарч одов.

Бильбо үг хэлж байхдаа халаасандаа гараа хийсэн нь өчнөөн олон жил нууж, нүдний цөцгий мэт хайрлаж байсан тэр бөгжөө тэмтэрч байжээ. Сандлаас буунгуут бөгжөө хуруундаа угласан ба тэр мөчөөс хойш Хоббитан оронд хэн ч түүнийг хараагүй гэдэг.

Асарт үлдсэн зочид яаж шаагилдаж байгааг, онцгой урилга аваагүй хоббитууд яаж байдгаараа хөгжилдөж байгааг инээмсэглэн сонсч байгаад тэр байшиндаа орж, баярын өмсгөлөө тайлж, торгон хантаазаа эвхээд цаасанд нямбайлан боож хайрцагт хийв. Дараа нь нэг навсархай хувцас хурдан углаж, хуучин ширэн бүсээ бүслэв. Бүсэнд нь элэгдсэн хуйтай богино илд зүүлттэй байлаа. Бильбо нэг санаа алдаад нафталин нэвт шингээсэн шүүгээнээс эртний юүдэнтэй цув гаргаж ирэв. Нэлдээ толбо болж, нэгэн цагт хар ногоон өнгөтэй байсан бололтой ч өнгөгүй болтлоо цайсан тэр цувыг үнэт эрдэнэ мэт хадгалж байжээ. Хувцас нь жаахан томдож байв. Тэгээд өрөөндөө орж, нууц хайрцагнаас даавуунд боосон нууцлаг зүйл, гар бичмэл бүхий ширэн хавгас, нэг зузаан дугтуй гаргаж ирлээ. Гар бичмэл, боодолтой юм хоёроо өрөөний голд байсан том үүргэвчтэй юм руу чихэж, дугтуйд гинжтэй алтан бөгжөө хийж, тамга дараад Фродод хаяглаж, задгай зуухны дээр тавив. Тэгснээ гэнэт шүүрч аваад халаас руугаа хийчихэв. Тэгтэл хаалга нээгдэж, Гэндальф хурдан хурдан алхлан орж ирлээ.

- Сайн уу, яагаад үзэгдэхгүй байгаа юм бол гэж гайхаж байлаа шүү - гэж Бильбо хэлэв
- Одоо чи харагдаж байгаад баяртай байна – гэж шидтэн сандалд суунгаа хэлээд - чинийхээр бол одоо бүх юм хэвийн байна уу?
- Тэгэлгүй яах вэ, харин тэр гал, гэрэл л илүү байлаа, би хүртэл гайхсан шүү, бусад хүмүүс ч ангайж хоцорсон л доо. Мэдээж, чиний ажил биз дээ?
- Мэдээж минийх. Чи бөгжийг олон жил дэмий нэг хадгалаагүй юм байна, зочид чинь чамайг алга болчихов уу, тоглоом хийв үү гэж ухааныхаа хэрээр тааж л байг.

- Миний тоглоомыг баллачихлаа

- Тоглоомыг чинь биш ээ, тэнэг үйлдлийг чинь... гэвч одоо энэ тухай ярих оройтсон. Садан төрлүүдийнхээ санааг зовоочихлоо, одоо чиний тухай Хоббитан даяар ерэн есөн хоног чалчих болно.

- Чалчицгааж л байг. Надад амралт хэрэгтэй байна, урт амралт, би чамд ярьсан шүү дээ. Хугацаагүй амралт гэж: хэзээ нэгэн цагт би эргэж ирэх болов уу? Яах ч гэж ирэх юм билээ, бүгдийг хийчихсэн... Хөгширчээ би, Гэндалф. Тийм ч их биш мөртөө л яс янгинаж байна. “Хэвээрээ байна” гэнэ шүү- гээд тэр нулимж - Чи ойлгож байна уу, би харамчийн талхан дээр түрхсэн шар тос шиг болж. Энэ муу. Амьдралаа яаж ийгээд өөрчлөх хэрэгтэй байна.

Гэндалф түүнийг анхааралтай харцаар цоо ширтэж байв.

- Тийм ээ, үнэхээр муу байна – гэж тэр бодлогошронгүй хэлээд - Чи бүгдийг зөв бодсон биз дээ?

- Тэр ч яахав, аль хэдийн шийдсэн асуудал. Би дахиад уул хармаар байна, ойлгож байгаа биз дээ Гэндалф, уул хармаар байна, үнэхээр амарч болох газар олмоор байна. Нам гүм, амар жимэр, элдэв түрэмгий хамаатан садангүй, зочидгүй, хаалганы хонх дарахгүй газарт очмоор байна. Номоо ч бичиж дуусгах хэрэгтэй байна. Би гайхамшигтай сайхан төгсгөл олсон: “... тэгээд хоногийн тоогоо гүйцтэл амар тайван амьдарчээ”.

Гэндалф тачигнатал инээв.

- Муугүй төгсгөл байна. Даанч яаж ч төгсгөлөө гэсэн унших хүн байхгүй.

- Хэрэгтэй нэг нь уншина биз. Төгсгөлгүй ч гэсэн Фродо уншчихсан. Фродо гэснээс чи тэрнийг харж хандана биз дээ?

- Тэрэнтэй манатай болоод байгаа ч гэсэн би тэрнээс нүд салгахгүй ээ.

- Тэр ганц хэлэхэд л намайг дагаад явах байсан нь мэдээж. Тэр ч бүү хэл найрнаас бүр өмнө өөрөө гуйж байсан. Гэвч одоохондоо энэ бүхэн зөвхөн ам. Би үхэхийнхээ өмнө дахиад зэлүүд бөглүүд газар ус, уулс үзмээр байна, харин тэрний зүрх энд Хоббитанд: тэрэнд жижигхэн нуга, бяцхан төгөл, горхи булагхан хэрэгтэй. Би тэрэнд элдэв хэрэггүй юмнаас бусад бүхнээ

үлдээсэн, тэр дасахаараа жаргалтай байх болно гэдэгт итгэж байна. өөрөө эзэн болох цаг нь ирсэн.

- Бүгдийг үлдээсэн үү? Бөгжийг ч гэсэн үү? Чи тэгж шийдсэн шүү дээ, санаж байна уу?

- М-мэдээж бүгдийг, а-а-а бөгж – гээд Бильбо гэнэтхэн гацав.

- Бөгж хаана байна?

- Мэдмээр байгаа бол дугтуйд, тэр задгай зуухан дээр – гэж Бильбо уурлаж эхэлснээ - үгүй ээ, тэнд биш, миний халаасанд байгаа – гээд инээж – хачин юм даа, гэхдээ хачин юм юу байна? хүсвэл орхино, хүсэхгүй бол орхихгүй - гэж бувгнав.

Гэндальф түүн рүү харахад нүдэнд нь өчүүхэн оч гялсхийв.

- Миний бодлоор бол бөгжийг орхисон нь дээр Бильбо минь, чи хүсэхгүй байгаа юм уу?

- Өөрөө ч мэдэхгүй байна. Одоо надад яагаад ч юм тэрнээс салмааргүй санагдаад байна. Ер нь яах гэж? Чи юу гэж над руу давшлаад байгаа юм бэ? Миний бөгж чамд амар заяа үзүүлдэггүй юу? Би юу олсон нь чамд ямар хамаа байна? гэж тэр ууртай бөгөөд сэжиглэсэн байдалтай бараг чихарсан тасалданги дуугаар асуув.

- Тийм ээ, амар заяа өгөхгүй байна – гэж Гэндальф зөвшөөрөөд – Би үнэнийг чамаас их удаан шалгааж мэдэж авч байна. Шидэт бөгж гэдэг бол шидтэй л байдаг юм, янз бүрийн далд аюул, санамсаргүй явдал дагуулсан байдаг юм. Чиний бөгж онцгой сонин байна, нуугаад яахав. Хэрэв чи аялалд гарахаар шийдсэн бол би тэр бөгжийг хараанаасаа гаргаж болохгүй. Чи түүнийг хэтэрхий удаан эзэмшиж байгаа юм биш үү? Надад итгэ Бильбо, одоо тэр чамд хэрэг болохгүй.

Бильбогийн нүүр улайж, Гэндальф руу хилэнтэй харц чулуудав. Түүний эелдэг царай гэв гэнэт хэрцгий болж хувирлаа.

- Чи яаж мэддэг юм бэ? Чамд ямар хамаатай юм бэ? Миний юм бол миний юм. Минийх, ойлгов уу? Би түүнийг олсон юм. Тэр миний гарт өөрөө ороод ирсэн юм.

- Мэдээж, гэхдээ яагаад ингэж догдлоод байна?

- Чи л намайг догдлуулаад байна. Минийх гэж чамд хэлээд байна. Минийх, Миний “Эрдэнэ”. Тийм ээ, чухам миний “Эрдэнэ”.

Гэндальф тайван, ихэд анхааралтай харахад нүдэнд нь гайхаж түгшсэн оч гялсхийв.

- Бөгжийг ингэж нэрлэж байсан удаа бий. Гэхдээ чи биш.

- Тэгэхэд би биш, одоо бол би. Тэгээд юу гэж? Хорлум тэгж хэлээ л биз. Бөгж тэрнийх байсан, одоо минийх, үүрд минийх.

Гэндальф босч ирэхэд дуу нь ширүүн болсон байв:

- Болгоомжил Бильбо, бөгжийг тавь. өөрөө хүссэн зүг рүүгээ яв, чи чөлөөтэй болно.

- Зөвшөөрч байгаа юм биз дээ, баярлалаа. Би өөрөө өөртөө эзэн – гэж Бильбо зөрүүдлэн хашгирав.

- Аядаарай, аядаарай эрхэм хоббит – гэж Гэндальф түргэн хэлээд - чиний насан туршид бид найз байсан, санаж үз. За түргэл, амласан ёсоороо бөгжийг тавь!

- Чи бөгжийг өөрөө авах гэсэн байх нь ээ? Үгүй шүү! Чи түүнийг авахгүй! Би чамд “эрдэнээ” өгөхгүй, ойлгов уу чи? – гэж Бильбо хашгираад богино илднийхээ бариулыг атгав.

Гэндальфын нүд гялалзав:

- Би ч гэсэн уурлаж чадна – гэж тэр анхааруулаад – Болгоомжил, тэгэхгүй бол Саарал Гэндальф уурлахыг үзнэ шүү! - гэв.

Тэр хоббит руу нэг алхахад бие нь үлэмж томорч, сүүдэр нь өрөө дүүрэн болов.

Бильбо арагш ухарч, амьсгаа нь түргэсэн гараа халааснаасаа гаргаж чадахгүй байлаа. Тэр хоёр бие биеийнхээ өөдөөс харж, агаар аяархан жингэнэж байв. Гэндальф харцаараа хоббитыг хананд шахаж, Бильбогийн атгасан хуруунууд тэнийн, тэр чичирч байв.

- Чи яах нь энэ вэ? Гэндальф, чи огт биш юм шиг. Юу болоод байгаа юм бэ. Энэ чинь минийх биз дээ? Би үүнийг олсон, энэ бөгж байгаагүй бол Хорлум намайг алах байсан. Би хулгайч биш, би үүнийг хулгайлаагүй, тэр миний араас юу гэж хашгирах нь ямар хамаатай юм бэ?

- Би чамайг хулгайч гээгүй. Би ч бас дээрэмчин биш, би чиний “эрдэнээ”-ийг авч байгаа юм биш, чамд л тусалж байна. Чи надад урьдынх шигээ итгэсэн нь дээр – гэж хэлээд тэр эргэхэд сүүдэр нь багасч Гэндальф дахин хөгшин, ядрангуй, бөгтөр, санаа нь зовсон өвгөн болов.

Бильбо алгаараа нүүрээ шувтраад:

- Намайг уучил, намайг нэг юм дайрах шиг боллоо. .. Одоо зүгээр юм шиг байна. Ер нь би эртнээс ийм болсон: хэн нэгний харц намайг хайгаад ч байгаа юм шиг. Дандаа л энэ бөгжийг зүүгээд л алга болчихмоор санагддаг байсан, тэгээд л би дандаа барьж үзэж, гаргаж хардаг болсон юм. Хайрцганд нуух гэж үзсэн, гэвч бөгж халаасанд байхгүй бол би тайван байж чаддаггүй байсан. Одоо би үүнийг яах вэ гэдгээ мэдэхгүй байна...

- Тэгвэл би мэдэж байна, одоохондоо шүү дээ. Зүгээр л бөгжийг энд орхичихоод яв. Түүнээс татгалз. Фродод өгчих, дараа нь яах вэ гэдэг миний хийх ажил.

Бильбо шийдэж чадахгүй нам зогсч байснаа санаа алдав.

- За яахав, өгье – гэж ихэд хүчлэн байж хэлснээ – мөрөө хавчиж, гэмшилтэйгээ инээмсэглэснээ – үнэнийг хэлэхэд яах гэж найр хийсэн бэ гэхээр аль болохоор их бэлэг тараах

гэж, далимд нь ... гэсэн юм. Ингэвэл дээр юм шиг санагдсан. Дэмий л байж, гэвч одоо хийснээ гүйцээх хэрэгтэй.

- Гүйцээхгүй юм бол эхлэх хэрэггүй байсан.

- За яахав, бөгжийг бусад зүйлсийн хамт Фродод өвлүүлж үлдээе. Миний явах цаг боллоо, хэн нэгэнд харагдах хэрэггүй. би бүгдтэй салах ёс гүйцэтгэсэн – гээд гүн санаа алдсанаа үүргэвчээ аваад үүд рүү чиглэв.

- Бөгж халаасанд чинь байгаа шүү дээ – гэж шидтэн сануулав.

- Байгаа, гэрээслэл бусад бичиг цаас ч байгаа. Бүгдийг нь аваад өөрөө зохицуул.тэгвэл найдвартай – гэж Бильбо хашгирав.

- Үгүй ээ, надад бөгж өгөх хэрэггүй, задгай зуух дээр тавь, Фродо одоо ороод ирнэ. Би хүлээж байна – гэж Гэндальф хэлэв.

Бильбо дугтуйг халааснаасаа гаргаж ирээд цагны дэргэд тавих гэтэл гар нь чичирч дугтуй шалан дээр уналаа. Гэндальф нүд ирмэх зуур ухасхийж дугтуйг аваад байранд нь тавилаа. Хоббит дахиад л уур нь дүрэлзэв. Гэвч төдхөн царай нь гэгээрч, нэг их сайхан инээмсэглэв.

- За ингээд болох нь тэр – гэж тэр санаа нь амарсан байдалтай хэлээд – Явъя даа – гэв.

Тэд үүдний танхимд ороход Бильбо хайртай таягаа аваад исгэрч дохио өглөө. Тал талын хаалгануудаас гурван гном гараад ирэв.

- Бүгд бэлэн үү? Боож, бичгийг нь бичсэн үү? - гэж Бильбо асуухад:

- Бэлэн – гэж гномууд хариулав.

- Тэгвэл хөдөлье гээд тэр хаалга руу алхлаа.

Цэлмэг сайхан шөнө, тэнгэрт одод гялалзана. Бильбо тэнгэр өөд хараад цээж дүүрэн амьсгаллаа.

- Нээрэн гэж үү? Дахиад л аян замд, хаашаа харсан зүг рүүгээ, гномуудтай гарч байна гэж үү? Хичнээн жил би ингэж мөрөөдсөн билээ! Хагацъя даа! гэж хэлээд тэр байшингийнхаа хаалга руу мэхийн ёслоод – Хагацъя даа Гэндальф! – гэв.

- Хагацъя биш ээ Бильбо, Баяртай! Болгоомжтой л яваарай! Чи бол юм үзсэн хоббит, мэргэн ухаантай ч байж магадгүй...

- Болгоомжтой байгаарай! Юу ч болоо билээ. Надад бүү санаа зов. Би жаргалтай байна, энэ юу гэсэн үг болохыг өөрөө ойлгож байгаа. Цаг ирлээ, зам минь дурайж байна.

Харанхуй, нам гүмийг цочоохгүй гэсэн шиг тэрбээр намуухнаар ийн дуулав:

Унаагүй аянчин би

Уй гунигаа орхиж

Урт аяндаа гарлаа

Үүднээс эхэлсэн зам

Үзүүргүй алсыг зорьж

Мянган замыг сүлжин

Мөрөн гол мэт долгилно.

Харин би тэр замаар

Хаашаа сэлж одохоо

Хараахан үл мэднэм зэ.

Хэсэгхэн зуур зогссоноо нэг ч үг унагалгүй, найр наадмын гал руу нуруугаа харуулан алхаж одоход араас нь гурван гном дагаж, цэцэрлэг рүү ороод тэндээс налуу зам руу оров. Ургаа модон хайсан завсраар гараад өндөр ургасан өвсөн дунд ороход сэвшээ салхи үлээх мэт өвсөн толгой ганхасхийгээд хоцорлоо.

Гэндальф гадаа зогсоод харанхуйд түүний араас харж байв.

- Баяртай Бильбо, эрхэм сайн хоббит минь – гэж тэр аяархан хэлээд байшинд эргэж орлоо.

Тэр даруй Фродо орж ирэхэд Гэндальф бүрэг харанхуйд гүн бодолд автан сууж байв.

- Явчихав уу?

- Явчихлаа, явж чадлаа.

- Уг нь... үгүй ээ юу л даа, би түүнийг үнэхээр явчихна гэж дотроо мэдэж байсан ч гэсэн зүгээр л тоглож байгаа юм байх гэж оройжингоо найдаж суусан юм. Ер нь их хатуу тоглоомтой хүн л дээ. Ингээд гаргаж өгч чадсангүй дээ.

- Үгүй дээ, тэр өөрөө үдэлт мүдэлтгүйгээр явахыг хүссэн байх. Бүү гутар. Одоо түүний бүх юм сайхан болно. Харин чамд нэг дугтуйтай юм үлдээсэн, тэр байна.

Фродо задгай зуух дээрээс дугтуйг авч үзсэн боловч нээсэнгүй.

- Наана чинь гэрээслэл гэх мэтийн бичиг баримтууд байх ёстой. Чи одоо Уугын хясааны эзэн, аа тийм наана чинь бас алтан бөгж байх ёстой.

- Юу? Бөгж өө?- гэж Фродо дуу алдаад - Түүнийгээ бас надад үлдээсэн хэрэг үү? Яагаад

ингэсэн юм бол? За за, хэрэг болно оо.

- Хэрэг болж ч магадгүй, үгүй ч байж магадгүй. Би чиний оронд байсан бол одоохондоо бөгжинд гар хүрэхгүй байсан. Тэрнийг сайн хадгал, хэнд ч бүү чалч. Би явж унтлаа.

Фродо нэгэнт аргагүйн эрхэнд эзний өмнөөс үүргийг нь гүйцэтгэх болсон тул зочдыг үдэн гаргаж, үлдэн хөөх хэрэгтэй боллоо. Хачирхалтай явдлын тухай мэдээ нугаар нэг тарсан тул Фродо ямар ч асуултад “өглөө аяндаа учир нь олдоно” гэсэн ганцхан хариу хэлж байв. Шөнө дунд онцгой хүндтэй зочдыг авахаар тэрэгнүүд ирэв. Тэрэгнүүд цадна цадна гэхэд дэндүү цадсан боловч сониуч зан нь ханаагүй хоббитуудыг аван ар араасаа харанхуй руу уусан одож байв. Хөл нь биеэ даахаа больсон зочдыг эрүүл саруул цэцэрлэгчид тэргэнцрээр зөөлөө.

Шөнө удаан өнгөрч, нар хоббитуудаас эрт боссон боловч өглөө болдгоороо боллоо. Уригдсан цэвэрлэгч нар ирж, асруудыг буулган, ширээ сандал, халбага сэрээ, аяга таваг, дэнлүү, цэцгийн сав зэргийг зөөж, хоолны үлдэгдэл, чихрийн цаасыг шүүрдэж, мартсан цүнх, бээлий, нусны алчуур, гар хүрээгүй хоолыг /ийм юм хүртэл үлдсэн байсан гээд бодчих/ цуглуулж эхлэв. Тэгтэл уригдаагүй Уутынхан, Талхынхан, Доргынхон, Молтогчингийнхон болон ойролцоо суудаг юм уу, буудалласан өчигдрийн зочдоос олон хоббитууд ирцгээв. Бага үд гэхэд өчигдөр хэрээсээ хэтэртэл зооглосон хүмүүс хүртэл ухаан орж, Уутан хясаанд урилгагүй зочин олноор цугларав.

Фродо инээмсэглэсэн мөртөө ядарсан, санаа зовсон царайтай тагтан дээр гарч ирэв. Тэр цугларагсадтай мэндлээд.

- Ноён Бильбо Торбинс тодорхойгүй чиглэлд явсан бөгөөд миний л сэдэж буйгаар тэр эргэж ирэхгүй - гэж баруун солгойгүй зарлав.

Зарим зочдыг тэр дотогш орохыг урив. Тэдэнд Бильбо “бэлэг” үлдээсэн ажээ.

Үүдний танхимд боодолтой, ороолттой зүйлс болон жижиг сажиг тавилга хэрэгсэл овоолоостой байсан бөгөөд бүгд цаасан зүүлттэй байв. Нэг иймэрхүү зүүлтүүд байна:

“Аделард Молтогчинд, түүний бүхэн эзэмшилд, Бильбогоос” гэсэн зүүлттэй шүхэр. Аделард олон жилийн туршид Бильбогоос хэдэн арван шүхэр ямар ч зүүлтгүй авч байжээ.

“Лора Торбинст, урт удаан захидал харилцааны чинь дурсгалд, хайрлан хүндэтгэгч Бильбогоос” гэсэн зүүлттэй асар том цаасан хогийн сав. Талийгаач үнэтийн дүү, Бильбо, Фродо хоёрын хамгийн ахмад садан Лора ерэн есөн настай бөгөөд тавин жилийг нь дотны хүмүүстээ сайн санааны зөвлөгөө бичин илгээж өнгөрүүлжээ.

“Милл Гүн-Ухагчид, гэнэт хэрэг болж магадгүй, Б.Т-оос” – алтан үзэг, лонх бэх. Милл хэзээ ч захидлын хариу өгдөггүй байжээ.

“Анжеликад Бильбо ахаас” – хөгжөөнтэй дүгрэг толь. Залуу бүсгүй Анжелика Торбинс хөөрхөн царайгаа бүх нийтийн анхаарлын төвд байх ёстой гэж боддог байжээ. “Гуго Их Гэдэстийн номын санг дүүргэхэд зориулав. Дүүргэгчээс” – номын тавиур /хоосон/. Гуго

бусдын номыг унших маш дуртай, хэзээ ч буцааж өгдөггүй байжээ.

“Любели Лякошель - Торбинст, бэлэглэв” – мөнгөн халбаганы цуглуулга. Бильбог Тийшээ ба Тэндээс аялж явахад Любели бараг бүх халбагыг нь гэр рүүгээ зөөсөн ажээ. Бильбо өөрийг нь халбаганы хулгайд сэжиглэж байгааг Любели сайн мэддэг байсан боловч тэр орж ирэхдээ бэлэгний зүүлтний далд утга юу гэж байгааг ойлгосон боловч бэлэглэсэн халбагануудаас цээрлэсэнгүй.

Энэ бол зөвхөн хэдхэн жишээ бөгөөд тэнд байсан бэлэг тоо томшгүй олон байв. Бильбо урт наслахдаа орон байраа нэлээд новшжуулжээ. Ерөнхийдөө хоббитын нүхнүүдэд хог новш илбийн юм шиг их хуримтлагддаг учир төрсөн өдрөөрөө аль болохоор их бэлэг тараадаг заншил үүссэн байж магадгүй. Тэр бэлэгнүүд заавал шинэ байх албагүй, тэр ч байтугай ямар зориулалттай нь үл мэдэгдэх нэг хоёр хог бүхэл тойргийг бүтэн тойрсон байв. Гэвч Бильбо голдуу шинэ зүйл бэлэглэдэг, бусдын бэлгийг дамжуулж бэлэглэдэггүй байв. Нэг үгээр хэлэхэд хуучны энэ нүх одоо бага зэрэг цэвэрлэгджээ.

Бүх бэлэг Бильбогийн өөрийн гараар бичсэн зүүлттэй, заримыг нь далд санаагаар бэлэглэсэн, заримыг нь зүгээр л шоглож бэлэглэсэн байв. Гэхдээ ихэнх нь хэрэг болох зүйл байлаа. Ядуу хоббитууд, ялангуяа Гадуур Уутынхан бэлгэнд сэтгэл хангалуун байв. Хөгшин Жихар Стромбид хоёр шуудай төмс, шинэ хүрз, ноосон хантааз, үе мөчний өвчний лонх эм өгчээ. Хөгшин Дурри Дэндүүдэлд олон удаа найрсаг зочломтгой байсныхаа төлөө арван хоёр лонх “Хуучин дарс”, өмнөд тойргийн чанга улаан дарс хүлээж авсан ба дарснуудыг бүр Бильбогийн эцэг өөрөө дарсан учир хангалттай удаан хадгалагдсан байв. Дурри уучлах ёстой байсан Бильбогийн нэг үйлдлийг тэр дороо уучлаад эхний лонхыг уусны дараа Бильбо бол жинхэнэ эр хүн гэж зарлав.

Фродо ч гомдох юм байсангүй. Гол хөрөнгө болох олон ном, зураг, янз бүрийн тансаг чамин тавилга түүнд өвлөгджээ. Гэлээ ч гэсэн тэнд мөнгө юм уу үнэт эрдэнэсийн ул мөр ч байсангүй, хэнд ч мөнгө, эрдэнийн чимэглэл өгсөнгүй.

Шинэ өдөр ажил ар араасаа ундарлаа. Бильбогийн бүх хөрөнгийг хямдруулан худалдана, тэр ч байтугай үнэгүй тараана, зүгээр л очоод авч болно гэсэн цуурхал тарав. Үнэгүй юманд дуртай хоббитууд бөөн бөөнөөрөө ирж, тэднийг Фродо ганцаараа тараах хэрэгтэй боллоо.

Хэрэмний хаалганаас үүдний довжоо хүртэл тэрэг, тэргэнцрүүд овооров.

Үйл явдал ид дундаа бужигнаж байхад Лякошел-Торбинсынхон ирлээ. Яг тэр үед Фродо түр амсхийхээр дотогш орж, өөрийнхөө оронд найз Мерри Дэндүүдэлдийг үлдээсэн байв. Одоо Лякошел “Бильбогийн үеэл дүү гээд байгаа тэр юмыг гаргаад ир” гэж чанга дуугаар шаардахад Мерри гараа алдлаад:

- Түүний бие тааруу байна – гэлээ.

- Энгийнээр хэлбэл үеэл дүү хэмээгдэгч нуугдаж байна. Бид хоёр тэрэнтэй уулзахаар ирсэн. Заавал уулзана. Ороод ингэж хэл – гэж Любели шаардав.

Мерри илтгэхээр орж, эр эм хоёр үүдний танхимд зөндөө зогсов. Эцэст нь тэр хоёрыг оруулахад Фродо баахан бичиг цаас овоолсон ширээний ард сууж байлаа. Царай нь тун базаахгүй, тун ч эелдэг биш байсан бөгөөд ширээний араас босч, гараа халаасандаа хийсэн хэвээрээ боловч хангалттай эелдэг ярилцаж байв.

Харин эр, эм хоёр нэн түрэмгий байлаа. Эхлээд тэд янз бүрийн эд хогшилд сохор зоосны үнэ санал болгов. Фродо бэлэг бэлгээрээ, харин энд юу ч худалдаагүй байна гэхэд тэр хоёр уруулаа жимийснээ энэ чинь туйлын сэжигтэй байна гэв.

- Надад нэг зүйл тодорхой байна, чи хэн хэнээс илүү энэ хөрөнгөөр гараа угааж байна, гэрээслэлийг нэн даруй үзүүлэхийг шаардаж байна – гэж Оддо үгэн дээр үг нэмлээ.

Хэрэв “үеэл дүү” байгаагүй бол энэ эдлэн Оддод олдох байжээ. Тэр гэрээслэлийг хоёр дахиж уншаад “түй” хэмээн нулимав. Гэрээслэлд бүх зүйл тов тодорхой, зөв бичигдсэн, найман гэрч улаан бэхээр гарын үсгээ нямбай зурсан байлаа.

- Дахиад л бид хоосон хоцорлоо. Жаран жил хүлээгээд дахиад л энэ. Тэр чамд юу бэлэглэлээ? Мөнгөн халбаганууд. Ёстой новш юм даа – гэж Оддо эхнэртээ хэлэв. Тэрбээр Фродо руу заналтайяа хараад гарч одов. Любели гарахыг яарсангүй, Фродо өрөөнөөсөө шагайж харвал тэр өнцөг булан бүрийг нэгжиж, хана, шал тогшиж байгаа харагдав. Фродо түүнийг хатуу гараараа үдэн гаргах замдаа бас шүхэрт нь санамсаргүй тээглэчихсэн жижиг боловч үнэтэй эдлэлээс салгалаа. Любели явахдаа ямар нэг аюултай юм хэлэх гэсэн бололтой, үүдний довжооноос эргэж хараад:

- Гайгүй ээ чи, ингэсэндээ харамсана даа муу гөлөг! Чи ер нь яах гэж энд үлдсэн юм бэ? Чиний байх газар энэ биш, чиний Ууг гэж юу байдаг юм бэ! Чи... чи бол жинхэнэ Дэндүүдэлдэн.

- Сонсов уу Мерри? Намайг яаж доромжилж байгааг – гэж Фродоо хаалга түгжих зуураа хэлэхэд:

- Ингэж доромжилдог юм уу, харин ч чамд ичгүүр сонжуургүй долигонож байна, чиний Дэндүүдэлдэн гэж юу байх вэ дээ – гэж Мерри Дэндүүдэлдэн хариулав.

Тэр хоёр дотогш орж, өрөө тасалгаануудаар яваад зоорь төнхөж байсан өсвөрийн хоёр хоббитыг (хоёр Талх, нэг Минж) хөөж гаргав. Том агуулахын шалыг тогшиж үзээд хөндий дуу гарахаар нь ухаан жолоогүй ухаж байсан Мэрэгч Үст Тавхайтай Фродо дээр доороо орон ноцолдож байж гаргав.

Бильбогийн эрдэнэсийн тухай цуу яриа хоббитуудын шуналт сонирхол, хий хоосон найдлагыг дэвэргэжээ: буруу замаар, муу аргаар олсон алтыг хэн ч булааж болно, зөвхөн амжих л хэрэгтэй гэсэн зарчим байдаг билээ.

Мэрэгчийг түлхэж гаргаад Фродо үүдний танхим дахь сандал дээр лагхийтэл суув.

- Мухлагаа хаая Мерри, хаалгаа түгжээд хэнийг ч бүү оруул, эвдвэл эвдэнэ л биз – гэлээ.

Аль хэдийн оройтсон оройн цайгаа уухаар суув уу, үгүй юу хаалга аяархан тогшлоо. “Дахиад л Любели, үгүй шүү, маргааш болтол хүлээж арай хатуу үг бодож олог” гэж өөртөө хэлээд, бүр чанга тогшихыг үл тоон цайгаа балгаж суув. Гэнэт цонхны цаана шидтэний царай харагдав.

Чи намайг яг одоо оруулахгүй бол Фродо минь би хаалгыг чинь авч хаяад зогсохгүй үүрийг чинь үнсэн товрог болгоно шүү - гэж тэр хашгирав.

- Гэндальф та юу? өршөөгөөрэй – гээд Фродо үүд рүү санд мэнд харайв – Орогтун, орогтун, би Любели л юм байх гэж бодлоо.

- Тийм бол ч яахав, өршөөе. Би сая тэр авгайг Голын хөндийд харсан, царай гэж авах юмгүй, одоо ч гэсэн амнаас эвгүй амтагдаад байна.

- Миний хувьд гомдол нэхэхгүй нь дээр. Үнэнээ хэлэхэд үзэгдэж харагдахгүй болмоор л байлаа, арай л Бильбогийн бөгжийг углачихсангүй.

- Углаагүй чинь болж, сайн байна. Бөгжтэй болгоомжтой харьцаарай Фродо. Би тэрнээс чинь л болж ирлээ, чамд хоёр үг хэлэх гэсэн юм.

- Юу гэж?

- Чи бөгжний тухай юу мэдэх вэ?

- Бильбогийн ярьсан бүхнийг, яаж олсон, яаж хэрэг болсон гээд л бүх түүхийг нь.

- Тэр чамд чухам ямар түүх ярьсан юм бэ?

- Гномуудад ярьсан нь биш, номондоо бичсэн нь ч биш – гэж Фродо хэлээд - Намайг энд ирэнгүүт тэр бүгдийг үнэнээр нь ярьж өгсөн. Нэгэнт та түүгээр бүгдийг яриулсан бол би ч бас үнэнийг мэдэх ёстой. “Чи бид хоёрын хооронд бүх юм үнэнээрээ байг Фродо минь, харин чи амаа л хамхиж яваарай, тэртэй тэргүй бөгж одоо минийх” гэж тэр хэлсэн.

- Бүр сонин болж байна – гэж Гэндальф хэлээд – харин энэ бүхэн чамд ямар санагдаж байна – гэж асуув.

- Та нөгөө “бэлэг”-ний тухай зохиолыг ярьж байна уу? Шал дэмий, утгагүй зохиол доо. Гол нь Бильбо тэгж ярьсан гэж бодохоор сонин байдаг юм, би анх сонсоод их гайхсан шүү.

- Би ч гэсэн их гайхсан. Гэхдээ шидэт эрдэнэсийн эзэд эрт орой хэзээ нэгэн цагт өөртэйгээ адилгүй болдог юм. Тэгэхээр чи машид болгоомжтой бай. Энэ бөгжийг чамайг дуртай цагтаа алга болж байг гэж хийгээгүй, тэгэхээр үүнд өөр чанар байгаа.

- Нэг л ойлгомжгүй байна даа.

- Надад ч гэсэн ойлгомжтой биш байна. Энэ бөгж өчигдөр орой л надад жинхэнээсээ сонин санагдсан. Гэхдээ чи бүү ай, би зохицуулчихна. Миний зөвлөгөөг дага, бөгжийг далдхан

хийчих. Гол нь тэр тухай яриа үүсгэж болохгүй. Дахиад хэлье, түүнийг сайн хадгал, түүний тухай нэг ч үг чалчив.

- Ямар сонин юм бэ, тэр ямар аюул тээж байгаа юм бэ?

- Би өөртөө итгэлтэй биш байгаа болохоор ярихгүй. Гэхдээ дараачийн удаа чи надаас баг сага юм сонсох байх. Одоохондоо баяртай, би явлаа- гээд Гэндальф босоход Фродо:

- Юу гэсэн үг вэ, би таныг манайд ядаж ганц долоо хонох байх гэж бодсон юмсан, таны тусламжид мөн ч их найдсан юмсан.

- Би тэгж л бодож байсан, гэвч болсонгүй. Би ирэхгүй их удах байх, гэвч эцсийн эцэст чам руу заавал ирнэ ээ. Би нууцаар ирэх учир ямар ч үед угтахад бэлэн байгаарай. Хоббитуудын нүдэнд харагдмааргүй байна, тэд надад их дургүй байгааг би харж байна. Надаас болоод муу муухай юм ирдэг гэж ярьцгаадаг. Надаас өөр хэн Бильбог төөрөгдүүлсэн бэ, аягүй бол энэ ертөнцөөс тонилгосон ч байж магадгүй. Чи бид хоёр хуйвалдаж, одоо түүний баялгийг хуваалцаж байгаа гэсэн шүү.

- Ярьцгааж л байг. Оддо, Любели хоёр л биз. Түй, муу хогнууд. Би энэ Уутан хясааг, энэ ертөнцийн бүх юмыг дуртайяа тавьж өгөөд оронд нь Бильбог ирүүлэх юм уу түүнтэй хамт явахад бэлэн. Би төрөлх газар орондоо хайртай, гэвч тэрэнтэй дэмий л зууралдлаа даа. Хэзээ нэгэн цагт би тэрнийг харах болов уу, үгүй л байх даа.

- Би ч гэсэн тэрэнтэй хэзээ уулзахаа мэдэхгүй байна, өөр олон юм мэдэхгүй байна. Болгоомжтой байгаарай. Намайг хамгийн тохиромжгүй цагт ирнэ гэж бодоорой. За баяртай.

Фродо түүнийг үүдний довжоо хүртэл гаргаж өгөв. Гэндальф гараа даллаад том том алхан одоход өвгөн шидтэнийг ямар нэг хүнд ачаа газар руу дарж байгаа юм шиг Фродод санагдлаа. Үдшийн бүрийд түүний саарал цув уусан алга болов.

Тэр хоёр дахин уулзтал их цаг урсчээ.

Бүлэг 2

Өнгөрсөн үеийн сүүдэр

9 хоног ч, ерэн есөн хоног ч яриа хөөрөө дууссангүй. Бильбо Торбинс хоёр дахь удаагаа алга болсон тухай зөвхөн Норгорд төдийгүй хаа сайгүй ярьцгааж, жил гаруй хэл амаа билүүдэцгээв. Энэ түүх хүүхдүүдийн үдшийн үлгэр болж, бөөн сүр дуулиантай алга болоод баахан эрдэнэстэй хүрч ирсэн галзуу Торбинс үлгэрийн баатар болж, үнэн үйл явдал бүрмөсөн мартагдахад үлгэртээ үүрд үлджээ.

Бильбо угаасаа эрүүл биш байсан, одоо бүр ямар ч найдваргүй галзуурсан, хаа нэгтээ ямар нэг цөөрөм юм уу гол руу унаж үхсэн биз, тэр нь ч дээр гэж нэг хэсэг ярьцгаав. Энэ бүхэнд хэн буруутай вэ гэвэл мэдээж нөгөөх Гэндалф.

“Тэр тэнэг шидтэн ядаж Фродог зөнд нь орхиосой, уул нь гайгүй ухаантай хоббит болж мэдэх байсан юм” гэж арай ухаантай нэг нь толгой сэгсрэн ярьдаг байв. Бүх талаар бодоход шидтэн Фродог зөнд нь орхисон бололтой ч гэсэн ухаантай хоббит биш байлаа. Тэр яг Бильбо шиг нэг л хачин байв. Тэр Бильбогийн дурсгалыг хүндэтгэж эмгэнэлийн ёслол хийсэнгүй, харин ч жилийн дараа Бильбогийн нэг зуун арван хоёр насны ойг өргөн дэлгэр тэмдэглэв. Гэвч хорьхон хүн уригдсан баярыг ямар баяр гэх билээ дээ. Гэхдээ хоббитуудын ярьдгаар хахталаа идэж, унатлаа уужээ.

Зарим нэг нь гайхаж байсан боловч Фродо Бильбогийн төрсөн өдрийг заавал тэмдэглэдэг заншилтай болж, үүнд нь хүмүүс дасчээ. Бильбо амьд арзайж, мэнд мэлтийж байгаа гэж тэр ярьдаг боловч хаана байгаа юм бэ гэж асуухаар мөрөө хавчаад өнгөрдөг байв.

Тэр Бильбогийн адил онцгой содон амьдардаг боловч найз нар, ялангуяа идэр залуу найз нар олон байлаа. Тэдний эдлэнд Ногоон Молтогчин (найз нар нь зүгээр л Ног гэдэг) болон Мерри Дэндүүдэлдэн (бүтэн нэр нь Мериада боловч хэн ч тэр нэрийг нь санадаггүй) гэртээ байгаа юм шиг л байдаг байв. Фродо тэр хоёртой уул хад, тал хөндийгөөр зугаалдаг боловч их төлөв ганцаараа тэнэдэг, яагаад энэ хүний нойр хүрдэггүй юм бол гэж энгийн хүмүүс гайхдаг байлаа. Мерри, Ног хоёр түүнийг Бильбо ахынхаа жишээгээр эльфүүдтэй холбогдсон гэж сэжиглэдэг байв.

Цаг хугацаа өнгөрөөд л байдаг, Фродо “хэвээрээ л байдаг”, дөнгөж гуч гарсан юм шиг хөнгөн шингэн эрүүл чийрэг хэвээрээ байлаа.

“Азтай хүн жаргалтай” гэж түүний тухай ярьдаг байсан ч тавь дөхөөд ирэхээр нь хүмүүс нэг л болгоомжилдог болчихов.

Фродо өөрөө анх сэтгэл гутруу байснаа болиод ноён Торбинс,

Уутан хясааны эзэн байх гэдэг их аятайхан болохыг мэдэв. Тэр арван жил зүгээр л амьдралын сайхныг мэдэрч, ирээдүйн тухай огт боддоггүй байсан бөгөөд хааяа Бильботой хамт яваагүйдээ жаахан харамсдаг байв. Яваандаа, ялангуяа намар цагаар түүнд огт үзээгүй орон

газар үзэгдэж, хэзээ ч харж байгаагүй уулс, сонссоноос цаашгүй тэнгис далай харагддаг болов. Тэгээд “нэг л өдөр Голоос цааш явна” гэж өөртөө давтан хэлдэг болсон ч тэр дороо л “дараа нэгэн цагт” гэж дотор дуу хоолой нь түүнд хэлдэг байв.

Тэгсээр тавин нас дөхөж, Фродод тавин нас их л чухал (тэр ч байтугай аюултай) юм шиг санагдаж байлаа. Бильбо яг энэ насандаа алсын аянд гарсан билээ. Фродо нэг л тайван бус болж, танил зөрөг замуудаас уйдаж эхлэв. Тэр Хоббитан орны газрын зураг харж үзэж хараагүй газруудыг хайдаг болов. Ганцаар зугаалах нь ихэсч, Мерри болон бусад найзууд нь түүнийг сэтгэл түгшин ажигладаг болов. Тэгэхдээ Фродо Хоббитанд хаа сайгүй тааралдах болсон харийнхантай урт яриа дэлгэдэг болсон байв.

Хилийн чанадад ямар нэг хачин юм болж байгаа тухай цуу тарж байсан ба Гэндальф өчнөөн олон жил үзэгдэхгүй болсон тул Фродо сонссон үг бүхнээ цэгнэдэг болжээ. Хоббитан орноор эльфүүд олноороо хөлхөх болов. Урьд нь тэдний тухай сонсч байснаас биш харж байсангүй, гэтэл одоо тэд орой үдэш ойн захаар яваад л, эргэж ирээд л байх болжээ. Тэд өөрсдийн хувь заяагаа дагаж, Дундад газрыг орхин одооцгоож байв. Бас гномууд олноороо хөлхөлдөнө. Дорноос өрнийг чиглэсэн эртний зам Хоббитаныг дайран өнгөрч Мөнгөлөг Боомтыг чиглэдэг бөгөөд гномууд энэ замаар эртнээс нааш хөлхөж, Цэнхэр уулс руу оддог байлаа. Хоббитууд харь хязгаар нутагт юу болж байгааг сонсдог боловч энэ орны эзэд тийм ч сониуч биш, ирж одогсод ч бас яриасаг биш байв. Гэвч Фродотой бүр холын орноос ирсэн гномууд улам их тааралдах болсон ба өрнө зүг рүү явж байгаа тэд Дайсан болон Мордор орны тухай шивнэн ярьдаг байв.

Энэ үг зөвхөн маш эртний домгуудад л гардаг, Гэгээн Зөвлөл Шивэр ойгоос муу үйлтнүүдийг хөөж гаргахад тэд өөрсдийнх нь эртний нутаг Мордорт суурьшсан, Хар Балгасыг дахин барьж, тэндээс Дундад газар руу харанхуй хүйтэн айдас тархаж, газар сайгүй дайн болж байлаа. Ууланд орхууд үржин олширч, троллууд урьдынх шигээ маанаг, майжгар биш, зальжин, бас шинэ зэвсэгтэй болжээ. Бүр ч аймшигтай зүйлийн тухай бүрэг бараг яриа ч дуулдах болов.

Энгийн ардууд тэр тухай бага мэдэж байсан нь мэдээж боловч хамгийн дүлий чихтнүүд ч ямар нэг юм сонссон, хил дээр очсон зарим нь бүр нүдээрээ үзсэн байлаа.

Хаврын нэг үдэш Фродогийн цэцэрлэгч Сэм Скромби ”Ногоон Луу” уушийн мухлагт тээрэмчний хүү Тод Доргитой яриа дэлгэж, мухлагийн байнгын үйлчлүүлэгчид тойрон сууцгааж байв.

- Одоо ч хачин хачин юм дуулдах болж дээ – гэж Сэм хэлэхэд Тод:

- Чихээ сайн дэлдийлгэ, тэгвэл тэр байтугайг дуулна. Манай чавганц дээр очиход л яриад өгнө - гэв.

- Чавганцын яриаг ч заримдаа сонсоход илүүдэхгүй. Чавганц өөрөө зохиож яриагүй, жишээ нь тэр луунуудын тухай.

- Тэр луунуудаа өөрөө ав, надад хэрэггүй. Би тэдний тухай өмдгүй гүйж явахдаа хангалттай

сонссон. өмд өмссөн цагаасаа тэр талаар бодохоо ч мартчихсан. Манай Голын хөндийд ганцхан луу бий, тэр нь ногоон гээч. Би зөв ярьж байна уу – гэж Тод хэлээд сонсогчид руу харахад өнөөдүүл нь тачигнатал хөхрөлдөв.

- За тийм байж гэж бодъё, тэгвэл аварга моднуудыг яах вэ? Хойд намгийн цаана нэг явж байна гэсэн, ямар ч модноос өндөр.

- Хэн тэгж ярьж байна?

- Наанадаж миний дүү Хэлл. Тэр ноён Минжийнд ажилладаг болохоор байнга хойт тойрогт байдаг юм. Тэгээд л үзсэн байхгүй юу.

- Тэр үзсэн байг, гэхдээ бидэнд үзүүлэхгүй. Тэр тэнд юугаа харна, тэрийгээ л хараг, тэртэй тэргүй бидэнд харагдахгүйгээс хойш.

- Нээрэн шүү, жинхэнэ аварга мод, нэг алхахдаа гурван сажин хол алхана, яг аварга том нарс шиг, тэгсэн мөртөө яваад байдаг.

- Нарс явдаггүй юм, ургасан газраа байж л байдаг юм.

- Тэнд чинь нарс ургадаггүй газар, явж байсан гэж хэлээд байна шүү дээ чамд

- Ургадаггүй юм бол хаанаасаа гараад ирдэг байна? – гэж Тод асуухад нөгөөдүүл нь Тодыг барж идэхгүй гэсэн аястай сайшаан хөхрөлдөв.

- Хэл чинь ч хурц юм аа, гэхдээ ганц манай Хэлл янз бүрийн юм хараагүй. Дорно зүгээс ер бусын харийнхан үй олноороо явж байгааг Хоббитан даяараа ярьж байна. Эльфүүд өрнө зүг хөдөлж, Цагаан цайзын цаадах боомтод хүрсэн гэж би сонссон – гээд Сэм өрнө хязгаарын цаадах эртний балгадын туурины чанад буй тэр тэнгисийг би ч мэдэхгүй, та нар ч мэдэхгүй гэсэн утгаар гараа даялав. Эльфийн хөлөг онгоцууд ирдэг, буцдаг Мөнгөлөг боомтын тухай эртний домгууд л байлаа. Тэр хөлгүүд ирээд л байдаг, өрнө зүг хөвөөд л байдаг, харин биднийг орхичихдог юм даа – гэж Сэм толгой сэгсрэн байж бараг л аялах шахам гунигтайяа бөгөөд ёслол төгөлдөр хэлэв.

- Шинэ маягаар найруулсан хуучин домог шив дээ. Ер нь та бид хоёрт тэр онгоцууд ямар хамаатай юм бэ? Хөвж л байг, явж л байг цаашаа. Хаа хүртэл хөвөх юм хэн мэдлээ. Ер нь хөвдөг ч юм уу, үгүй ч юм уу хэн мэдэх юм бэ?

- Би мэдэхгүй л дээ – гэж Сэм бодлогошронгуй хэлэв. Тэрбээр нэгэнтээ ойд явж байгаад эльфүүдийг харсан шиг санагдах юм. Хэн нэгэн тэднийг хараад асууж шалгаах байх гэж найдаж байсан санагдана. Багадаа сонссон домог яриануудаас эльфүүдийн тухай хэсэг бусаг юм ой тойнд нь үлджээ.

- Манай нутагт ч гэсэн тэр хачин хүмүүстэй ярьж чаддаг хүмүүс байдаг юм. Миний эзэн ноён Торбинс тэдний нэг нь байсан юм. Тэр надад эльфүүд яаж далайгаар аялдаг тухай ярьж өгдөг байсан юм, ер нь юм ярих л юм бол эльфүүдийн тухай ярьдаг байсан юм. Хөгшин

Бильбо тэдний тухай хорвоо дээрх бүх юмыг мэддэг байсан даа.

- Тэр хоёр хоёулаа солиотой. Хөгшин Бильбо бүр галзуурчихсан, одоо Фродо солиорч эхэлсэн. Та арай Фродогоос энэ бүхнийг сонссон юм биш биз? өөрөө солиорчихов доо. За залуусаа, хэн хаашаа явна хамаагүй, харин би харилаа, эрүүл энх байцгаагаарай – гэж Тод хэлээд нэг гүрүүшиг пиво залгилчихаад бүгдтэй салах ёс хийв.

Сэм дахиад жаахан суусан боловч хэнтэй ч үг сольсонгүй. Тэрэнд бодох юм байлаа. Маргааш өглөө цэцэрлэгт зөндөө ажил хүлээж байгаа, хувин л байвал болох нь тэр. Ажил яахав, ажил л биз. Сэм шал өөр юм бодож байлаа. Тэгээд нэг санаа алдсанаа босч мухлагаас гарлаа.

Дөрөвдүгээр сарын тэнгэр хэд хоногийн усан борооны дараа цэлмэв. Наран шингэж, сэрүүхэн үдэш сэмхэн алга болж шөнийн харанхуй залгав. Сэмийн толгой дээгүүр одод тодрон гялалзаж, тэрбээр бодолдоо автаж, дуулдах төдий исгэрэнхэн хэвгий дэнж өөд өгсөн алхав.

Тэр үеэр гэнэтийн зочин болдог Гэндальф гэнэт гараад ирэв. Бильбогийн найраас хойш тэр гурван жил үзэгдэхгүй байснаа нэг хүрч ирээд Фродог анхааралтай ажиглаж, ганц хоёр үг хэлээд хоносон ч үгүй яваад өгчээ. Тэгснээ байн байн ирэх болсон бөгөөд үдшийн бүрийгээр орж ирээд үүр цайхад бараа сураггүй алга болдог байлаа. Хаагуур юу хийж яваагаа хэлдэггүй, Фродогийн бие ямар байгааг асуугаад өөр хэнд ч хэрэггүй юм сонирхож байгаад явдаг байв.

Тэгснээ огт алга болоод есөн жил болсон ба хоббитуудыг тоохоо больсон юм байх гэж Фродо бодож байв. Гэтэл нэг орой харанхуй болж байх үеэр цонх тогшив.

Фродо хуучны найзаа ирсэнд чин сэтгэлээсээ баярлажээ. Тэр хоёр өөд өөдөөсөө харан зогсоод бие биеэ хэсэг ажиглав.

- За бүх юм хэвийн биз дээ? – гэж Гэндальф асуугаад - Чи ч гялалзаж байна аа гэв.

- Та ч гэсэн гялалзаж байна - гэж Фродо хэлсэн боловч дотроо шидтэн ихэд өтөлж, бөгтийсөн байна гэж бодлоо. Фродо шидтэнг асуултаар булж, тэр хоёр шөнө дөл болтол ярилцаж суулаа.

Өглөөний цайгаа оройтож уусны дараа нэлттэй цонхны дэргэд сууцгаалаа. Задгай зууханд гал цогшиж, нар ээж байсан ч өмнө зүгээс дулаан салхи сэвэлзэж, эргэн тойронд сэргэг агаар сэнгэнэж, тал хөндий ногоорон модод хурц ногоон навчаар гоёсон байлаа.

Гэндальф бараг наян жилийн өмнө Бильбо нусны алчуур ч авалгүй адал явдалт алс холын аянд гарахад ямар хавар болж байсныг дурсан ярив. Тэр цагаас хойш Гэндальфын үс цайж, сахал, хөмсөг нь саглайж, нүүрэнд нь шинэ шинэ үрчлээ нэмэгдсэн боловч нүд нь урьдынх шигээ гялалзан тамхины утаан цагариг сурамгай үлээж суулаа.

Тэрбээр таг дуугүй тамхиа сорж суухад Фродо ч дуугарсангүй, бодол болон суув. өглөөний тунгалаг сайхныг Гэндальфын хэлэх муу мэдээ бараантуулахыг тэр мэдэрч байв. Тэгээд өөрөө эхэлж дуугарахаар шийдэв.

- Та миний бөгжний талаар нэг юм хэлэх гээд байсан даа,

ярьж эхлээд дуусгалгүй орхисон. Одоо үргэлжлүүлэх юм биш үү? Та бөгжийг аюултай гэсэн, яагаад гэдэг нь надад ойлгомжгүй байна. Аюултай гэдэг чинь юу гэсэн үг вэ?

- За тэгвэл сонсч бай, энэ бөгж ямар ч цусан зүрхтэнг үгүй болгох чадалтай, үгүй болгоод өөрийн болгоно... Эрт урьдын цагт элэнцийн оронд эльфийн бөгжнүүдийг цугласан юм. Чиний хэлснээр ид шид шингээсэн тэр бөгжнүүд үнэхээр эгэл биш, нэг нь их хүчтэй, нөгөө нь арай бага хүчтэй. Арай бага хүчтэй нь зүгээр уран дархны өөрийгөө сорьсон сорил байсан, гэхдээ л тийм бөгжнүүд аюултай. Агуу их бөгж буюу бүхнийг эзэгнэгч бөгжнүүд үхлийн аюултай. Шидэт бөгжийг эзэмшүүлсэн цусан зүрхтэн үхдэггүй, гэхдээ жинхэнээр амьдардаггүй гэдгийг чамд хэлэх хэрэгтэй Фродо. Бөгжийг эзэмшсэн цусан зүрхтний амьдрал ямар ч баяр баясгалангүй, өдөр хоногийг зовж өнгөрүүлдэг юм. Хэрэв цусан зүрхтэн үзэгдэхгүй болохын тулд бөгжийг байн байн зүүгээд байвал хайлдаг буюу мэргэдийн хэлснээр задарч үүрд үзэгдэхгүй болдог, зөвхөн Бөгжний эзэнд л харагдана. Эрт орой хэзээ нэгэн цагт тэр Хар эзний хаанчлалд байдаг Хар хүчний зарц болно.

- Ямар аймаар юм бэ? – гэж Фродо хэлсний дараа хоёул таг дуугүй сууж, зөвхөн цэцэрлэгч Сэм Скробийн хайчны чимээ л цонхны цаанаас сонсдоно.

- Та энэ тухай аль эртнээс мэдэж байсан уу? Бильбо мэдэж байсан уу?

- Бильбо чамд ярьсан зүйлээ л мэдэж байсан. Тиймгүй сэн бол тэр чамд ийм аюултай өв үлдээхгүй байсан, надад ч найдахгүй байсан. Энэ бөгж маш гоё, ямагт хэрэг болно, хэрэв түүнд ямар нэг муу юм тохиолдлоо гэхэд бөгж үүнд ямар ч хамаагүй гэж тэр боддог байсан. Бөгж толгойноос огт гарахгүй, цаг үргэлж санаа зовоож байна гэж тэр надад хэлж байсан, гэхдээ бөгжнөөс болоод ингэж байна гэж тэр боддоггүй байсан. Гэхдээ бөгжийг сайн харж хамгаалах хэрэгтэй, заримдаа хүнд болдог, заримдаа хөнгөн болдог, хуруунаас мултартч унаад алга болчихож магадгүй гэж тэр мэддэг байсан л даа.

- Тийм ээ, надад энэ тухай бичиж байсан, би бөгжийг гинжлээд тэлээнээсээ зүүж явдаг.

- Ухаалаг байна, Бильбо урт насалснаа бөгжтэй холбож үздэггүй байсан, зүгээр л өөрийгөө урт наслах хувьтай юм байна гэж бодоод түүгээрээ их бахархдаг байсан. Тэгсэн мөртөө ямагт айж, түгшиж байсан. “Би маш нимгэн хальс шиг, хачин тунгалаг болчихлоо” гэж нэг удаа ярьж байсан. Дахиад жаахан удсан бол бөгж хийх юмаа хийх л байсан.

- Та үүнийг эртнээс мэдэж байсан уу?

- Үүнийг гэдэг чинь юу гэсэн үг вэ? Фродо минь би хэний ч мэдэхгүй олон юм мэднэ шүү. Хэрэв чи энэ бөгжний тухай асууж байгаа бол би одоо ч гэсэн бүгдийг мэдэхгүй. Сүүлчийн сорил үлдээд байна. Гэхдээ миний таамаг эргэлзээгүй үнэн. За байз, хэзээ би анх энэ тухай ухаарсан билээ? Аа тийм, Гэгээн Хүчний зөвлөл Балар шугуйг цэвэрлэсэн тэр жил, яг таван дайчны тулалдааны өмнөхөн шүү дээ. Яг Бильбо бөгжийг олсон үе. Надад нэг л жигтэйхэн түгшүүртэй болсон, яагаад тэгснийг би мэдээгүй. Тэр Хорлум яагаад Шидэт бөгжнүүдийг нэгийг эзэмшсэнийг би ойлгохгүй байсан юм, шидэт бөгжнүүдийн нэг гэдэг нь илэрхий

байсан л даа. Тэр Бильботой ярихдаа айхтар худлаа хэлсэн: “бэлэг” мэлэг ч гэх шиг. Дараа нь Бильбо надад үнэнийг хэлэхэд би ойлгосон, ойлгоод байх ч юу байх вэ, хоёулаа л бөгжийг эзэмших маргаангүй эрхтэй гэж нотлохыг оролдсон хэрэг, Хорлум “төрсөн өдрийн бэлгэнд авсан” гэдэг, Бильбо болохоор “шударга мөрийнд авсан” гэдэг. Яах аргагүй худлаа ярьсан, тэгэхдээ ийм адилхан худлаа ярьсанд нь би их санаа зовж байлаа. Бөгж худлаа яриулсан, худал үг зааж өгсөн нь илэрхий байгаа юм. Тэгэхэд л би тун ноцтой юм болж байгааг ойлгосон, тэгээд бөгжтэй болгоомжтой харьц гэж Бильбод хэлэхэд тэр миний үгэнд ороогүйгээр барахгүй надад уурласан. Тэгээд яалтай билээ, бөгжийг тэрнээс булаагаад авчихаж болохгүй. Тиймээс би анхааралтай ажиглаж, цагийг хүлээж байсан юм. Цагаан Сарумантай зөвлөх хэрэгтэй байсан юм, гэтэл яагаад ч юм би тэгээгүй.

- Тэр чинь юун хүн бэ, огт сонсоогүй юм байх чинь.

- Чи яаж мэдэх билээ, тэрэнд хоббитууд огт хамаагүй. Тэр бол агуу их мэргэн ухаантан, тэргүүн шидтэн, Зөвлөлийн тэргүүн. Тэр олон нууцыг нээсэн боловч мэдсэндээ эрдээд бүгдийн дээр гарсан юм. Тэр бөгжний нууцад эртнээс нэвтэрсэн, Зөвлөлд бөгжнүүдийн тухай ярихад түүний үг миний түгшүүрийг арилгасан юм. Гэлээ ч гэсэн би цагийг хүлээж ажигласаар байсан.

- Цаг хугацаа урсаад л байдаг, Бильбо хөгширдөггүй. Тэгэхэд дахиад би сэжиглэж эхэлсэн. Бильбогийн найрын үдэш хүртэл хүлээгээд л байсан. Бильбо ярьж эхлэхэд миний бүх түгшүүр сэргэж, маш том нууц байгааг би ойлгож, тэр нууцыг олон жил тайллаа.

- Гэвч аймшигтай юм болоогүй л байна шүү дээ, аажимдаа тэр ухаарч, тайтгарах байлгүй дээ – гэж Фродо айсан байдалтай хэлэв.

- Тэр бөгжнөөс салангуугаа тайвширсан, гэвч бөгжийг ганцхан хүч л захирч байгаа, бөгжний тухай бүхнийг мэдэж байгаа, бөгж эзэддээ ямар гай тарихыг мэдэж байгаа цорын ганц хүч л захирна. Харин хоббитуудын талаар хэн ч юу ч мэдэхгүй. Одоогоор ганцхан би л судалж байгаа, судлах тусмаа гайхаж байгаа. Заримдаа хайлсан тос шиг зөөлөн, заримдаа хөгшин модны үндэснээс ч хатуу. Зарим нь бөгжнүүдийг удаан эсэргүүцэж чадах боловч мэргэдийн зөвлөл итгэхгүй л болов уу. Тиймээс чи Бильбод бүү санаа зов. Тэр бөгжийг олон жил эзэмшсэн, олон ч удаа зүүсэн. Бөгж түүний амьдралд нэвт шингэсэн, тэр ул мөр мөддөө арилахгүй. Дахиж нүдэнд нь харагдахгүй байвал сайн сан. Бильбод би санаа зовохгүй байна. Харин одоо чиний ээлж, чиний хариулт өгөх цаг.

Чи миний санааг их зовоож байна, та нар бүгдээрээ сайхан санаатай, тэнэгдүү, цаад наадыг боддоггүй хоббитууд. Хэрэв энэ орныг харанхуй хар хүч залгиж, гайхамшигт гайхал Торбинсууд байтугай танай тэр тэнэг Минжүүд, Талхнууд, Их Гэдэстүүд цөмөөрөө хариугүй муу хулчгарууд, харанхуй хар туламнууд болчихвол энэ ертөнцөд их хохирол учирна.

- Яахаараа бид хулчгарууд, харанхуй хар туламнууд болдог билээ? Тийм барлагууд хэнд хэрэгтэй байх юм бэ?

- Бүх нийтийн дайсанд хэрэгтэй байх болно. Гэхдээ өдий болтол тэрний толгойд хоббитууд ороогүй байгаа, одоо болтол шүү. Үүний төлөө хувь заяандаа баярлах хэрэгтэй. Одооноос

эхлээд Хоббитан оронд аюул тулгарч байна. Та нар тэрэнд хэрэггүй, тэрэнд хангалттай олон боол бий, гэхдээ тэр та нарыг мартахгүй. Хөгжилтэй, эрх чөлөөтэй хоббитууд тэрэнд хэрэггүй, өөдгүй муу боол-хоббитууд хэрэгтэй. Түүнээс гадна тэр та нарыг занаж байгаа, түүний өшөө хонзон аймшигтай.

-Юун өшөө хонзон? Яалаа ч гэсэн үүнд Бильбо, би, бөгж ямар хамаатайг би ойлгохгүй байна.

- Яагаад хамаагүй гэж? Чи нэг юм ойлгохгүй байна, гэхдээ одоо ойлгоно оо. Би түрүүчийн удаа итгэлгүй байсан, одоо бүх юм тодорхой боллоо. Алив, тэр бөгжөө өгөөдөх.

Фродо өмднийхөө халааснаас бөгжөө гаргаж, тэлээн дэх гинжнээсээ салгаад шидтэнд дургүйхэн өгөв. Бөгж Гэндальфын гарт орохыг хүсэхгүй байх мэт хүндэрч байлаа.

Шидтэн бөгжийг болгоомжтой авч үзвэл цэвэр шар алтаар хийсэн байв.

- Ямар нэг тэмдэг байна уу?

- Ямар ч тэмдэг байхгүй, нэг зураас ч байхгүй.

- Хар даа – гээд шидтэн бөгжийг гал руу шидэв. Фродо галын хайч шүүрч авахад Гэндальф гараас нь бариад нүүр өөд нь ширүүн харж:

- Хүлээж бай гэж захирангуй хэлэв.

Бөгж хайлсангүй. Гэндальф босч, цонхны хөшгийг татав.

Тасалгаанд анир чимээгүй, харанхуй шахам болж, цэцэрлэгээс Сэмийн хайчны дуу л сонсдоно. Шидтэн бөхийж галын хайч аваад бөгжийг улаан цогноос гаргаж ирэхэд Фродо сая нэг амьсгаа авлаа.

- Цэв хүйтэн байна. Май – гээд Фродогийн алган дээр бөгжийг тавихад санамсаргүй хүнд байсанд Фродо цочин давхийв.

- Хуруугаар бариад сайн хар – гэж Гэндальф хэлэв.

Фродо бөгжийг барьж харахад дотор, гадна талд маш нарийн зурааснууд харагдав. Тэр зурааснууд галаар зурагдсан мэт боловч нэг л ойлгомжгүй, тод мөртөө бүдэг, гүнээсээ зурагдсан байв.

- Энэ галт үсгүүд надад ойлгомжгүй байна – гэж Фродо хоолой чичрүүлэн хэлэв.

- Чамд ойлгомжгүй ч гэсэн надад ойлгомжтой байна. Эртний эльф үсэг, мордор хэлээр бичсэн байна. Би тэр хэлээр энд яримааргүй байна. Нийтийн хэлээр энэ бичгийг ингэж орчуулж болно:

Нэг бөгж тэднийг захирна, тэднийг хураана,

Нэг бөгж тэднийг хар гинжинд хэлхэж давтана.

Энэ мөрүүд бол зөвхөн эльфүүдэд ойлгомжтой шүлэглэсэн хараал байна:

Гурван бөгжийг асар тэнгэрт суугч хаанлаг эльфүүдэд,

Долоон бөгжийг чулуун тэрэмд суугч гномуудын эздэд,

Есөн бөгжийг булшны хумхийн тоос өмсөгч Естүүдэд,

Нэг бөгжийг Мордор нэрт харанхуйн орноо

Хар ширээнээ залрагч Эзэн зүүх болой.

Нэг бөгж Мордор нэрт харанхуйн орноо

Тэднийг захирна, тэднийг хураана,

Нэг бөгж тэднийг хар гинжинд хэлхэж давтана.

Гэндальф гүнээ санаа алдаад:

- Чиний бөгж бол бусад арван есөн бөгжийг захирагч Их засагчийн бөгж байна. Энэ бөгж олон жилийн өмнө алдагдаж Дайсны засаглалд их хохирол учруулсан. Энэ бөгж түүнд энэ ертөнц дээр бүхнээс илүү хэрэгтэй, тиймээс энэ бөгжийг түүнд өгч болохгүй.

Фродо дорноос ирсэн хар үүл хүйтэн харанхуйгаар хучигдсан мэт айдастаа хүлэгдэн хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй сууна.

- Энэ чинь тэгээд Дайсны бөгж байх нь ээ? Тэгээд яаж, яах гэж надад ирдэг байна аа?

- За энэ ч их урт түүх дээ. Энэ бол зөвхөн мэргэд л мэдэх, тэхдээ бүгдээрээ ч мэдэхгүй хар жилүүдэд эхэлсэн түүх. Хэрэв эхнээс нь ярих юм бол бид хоёр намар болтол энд суух болно... өчигдөр би чамд бөгжнүүдийн эзэн Сауроны тухай ярьсан. Чиний чих үнэн сураг сонссон байна: тэр Балар шугуйг орхиж, өөрийнхөө эртний цайз –Мордорын шилтгээнд суусан. Мордор гэдэг үгийг чи мэднэ: бүр хоббитын түүх бичлэгт хүртэл айдас хүйдэс ханхлуулан байн байн гарч ирээд байдаг. Дахин дахин дайн тонуул болдог, дахиад нам тайван болдог, тэгээд Харанхуй зүсээ хувилгаж, дахиад хүч ордог юм.

- Ядаж намайг амьдад тийм юм бүү болоосой

- Миний амьдад тийм юм олон удаа болж байлаа. Амтай болгон л намайг амьдад тийм юм бүү болоосой гэдэг юм. Бид хувь заяагаа өөрөө сонгодоггүй боловч энэ удаа бидэнд цаг байна, гол нь энэ цагийг алдаж болохгүй. Бидний цаг бараг дуусах гэж байна шүү Фродо. Дайсан өдрөөс өдөрт улам хүчтэй болж байна. Түүнд дахиад хугацаа хэрэгтэй, тэр хугацаа нь урт биш. Тэрний санааг урьдаас мэдэж ер бусын тохиолдлыг ашиглах хэрэгтэй, магадгүй өөрөө үрэгдэж ч мэднэ.

Дайсан маш хүчтэй, гэвч эсэргүүцэл бүхнийг дарж, Дундад газрыг харанхуйд живүүлэхэд тэрэнд нэг юм дутна, тэр бол бүхнийг захирагч бөгж.

Хамгийн сайн гурван бөгжийг эльфүүд түүнээс нуусан, тэрний гар тэр гурван бөгжинд хүрч бузарлаагүй. Долоон бөгж гномуудад байсан, гурвыг нь тэр олж авсан, бусдыг нь луунууд сүйтгэчихсэн. Есөн бөгжийг нь тэр агуу бардам хүмүүст тарааж өгсөн, боолоо болгох гэж. Тэр хүмүүс аль эрт харанхуйн зарц, дайсны хамгийн аймшигтай харьяатууд болсон. Аль эрт... Аль эрт газар дээр есөн баатрыг хэн ч хараагүй. Гэвч хэн мэдэх вэ, харанхуй дахиад хүчээ авбал тэд ч гараад ирж мэднэ. Гэхдээ Хоббитан оронд, энэ сайхан өглөө тэднийг яриад яах вэ.

Одоо тэгэхээр есөн бөгж дайсны гар хөл бологсдод байгаа, долоогоос үлдсэн бөгжнүүд Мордорт хадгалагдаж байгаа. Гурав нь одоогоор далд хадгалагдаж байгаа, гэхдээ хамгийн гол нь түүнд хамгийг захирагч бөгж л чухал. Тэр энэ бөгжийг хийсэн, энэ бол тэрний бөгж, энэ бөгжинд түүний эртний их хүч шингэсэн байгаа. Хэрэв энэ бөгжийг олбол Сауроны хүч зуу дахин ихэснэ, эльфийн гурван бөгж ч түүнд захирагдана. Тэр дийлдэшгүй хүчтэн болно.

Бид аймшигт цагийн босгон дээр ирээд байна. Хамгийг захирагч бөгж алга болсон, эльфүүд түүнийг устгасан гэж Саурон бодож байсан юм. Харин одоо тэр бөгж олдсон, байгаа гэдгийг тэр мэдэж байна. Тэгээд бөгжөө хайж байгаа, түүний эрлийн үзүүр наашаа чиглэсэн. Түүний агуу их найдвар, бидний агуу их айдас энэ л байгаа юм.

- Энэ бөгжийг яагаад хайлаагүй юм бол? Хэрэв Дайсан тийм их хүчтэй, энэ бөгж түүнд тийм чухал юм бол яагаад алдсан юм бол?- гэжэ Фродо хашгираад бөгжийг авах гээд урт хар гар сунаж байгаа юм шиг тас атгав.

- Тэр бөгжийг их эрт цагт түүнээс салгасан, эльфүүдийн хүч чадал агуу их байсан, тэдэнтэй бас хүмүүс нэгдсэн байлаа. Бид эртний түүхийн энэ бүлгийг эргэж санахад илүүдэхгүй. Тэгэхэд гай зовлон харанхуй хар хүчин тулж ирсэн боловч өөдөөс нь агуу их гавьяат үйлс тулалдсан юм, тэр гавьяат үйлс талаар болоогүй. Би чамд тэр түүхийг нэг бус удаа ярьж өгч магадгүй, эсвэл чи надаас илүү мэддэг хэн нэгнээс сонсч магадгүй.

Харин одоо энэ бөгж Хоббитанд, Норгордод Уутан хясаанд яаж өнхөрч ирснийг чи мэдэх хэрэгтэй.

Эльфийн хаан Гил-Гэлад, баруун хязгаарын их ван Элендил хоёр хүч хавсарч Сауроныг унагасан боловч сүүлчийн шийдвэрлэх тулаанд хоёулаа баатарлагаар амь үрэгдсэн, Элендилийн хүү Исилдур Сауроны хурууг бөгжтэй нь тас цавчиж авсан юм. Ингээд Дундад газарт Сауроны сүнс сүүдэр үгүй болсон бөгөөд түүнээс хойш их олон эрин улирахад түүний сүүдэр Балар шугуйд дахин сүүмэлзэж эхэлсэн.

Бөгж сураггүй болсон. Их мөрөн Андуины усанд живсэн юм. Тэгэхэд Исилдур дайнаас эргэж, мөрний зүүн эргээр явж байхад нь манант уулнаас орхууд довтолж, бараг бүх дайчдыг нь хөнөөсөн. Исилдур бөгж зүүгээд үзэгдэхгүй болж, голоор сэлж гатлах гэсэн боловч бөгж хуруунаас нь мултарч усанд унасан.

Тэгээд бөгжний сураг тасарсан ба одоо миний ярьсан энэ түүхийг бараг хэн ч мэдэхгүй, Мэргэдийн зөвлөл хүртэл бөгж цаашид яасан талаар юу ч мэддэггүй юм. Харин би одоо огт өөр түүх ярина.

Дахиад хэдэн мянган жил өнгөрөхөд их мөрөн Андуйны хөвөөнд брендидуимын хоббитуудтай төстэй нэгэн омог оршиж байв. Тэр омгийнхон зэгс сүлжиж, мөрнөөр сэлдэг байсан. Тэр омогт нэг нэр хүндтэй том гэр бүл байдаг, өрхийн тэргүүн нь эртний заншил баримталдаг ширүүн дүртэй эмгэн байжээ. Тэр гэр бүлийн хамгийн авхаалжтай сэргэлэн нь Смеахорл гэгч байжээ. Тэр юм бүхнийг мэдэх гэж оролддог, мөрний ёроол руу шумбаж, ногоон толгодын доогуур ухаж, модны үндсийг хүртэл ил гаргадаг боловч дээшээ огт хардаггүй, моддын орой, уулын оргилыг ч үзээгүй, үргэлж газар шагайж явдаг байжээ.

Түүнд Деахорл нэртэй нэг найз байсан бөгөөд нүд хурц боловч тийм ч хүчтэй, зальтай, овсгоотой биш байж. Нэг удаа тэр хоёр завиар гол уруудан хөвж яваад өндөр, өтгөн ургасан бут, зэгсэн дунд ороод Смеахорл нь эрэг дээр гарч нуга дундуур шиншлэн одоход Деахорл нь завин дээр үлдээд загас барьжээ. Дэгээг нь нэг том загас гэнэт үмхэж, ганц ухасхийгээд Деахорлыг ус руу чирээд орчихжээ. Голын ёроолд нэг юм гялалзаж харагдахад тэр уургаа тавьж орхиод, нэг сайн амьсгал аваад доош шумбаж, гараараа тэмтрэн нөгөөх гялгар юмыг эрж олов гэнэ.

Тэгээд үсэнд нь усны ургамал орооцолдсон, гартаа шавар, замаг атгачихсан дээш гарч ирээд эрэг рүү сэлжээ. Эрэг дээр гараад гараа ус руу дүрж шаврыг арилгаад хартал алган дээр нь гайхалтай сайхан хийцтэй алтан бөгж байх нь тэр. Тэр бөгж наранд нэг л ер бусын сонин гялалзаж байсан тул Деахорл баярлан сонирхож байтал араас нь Смеахорл чимээгүй гэтээд иржээ. Тэр найзынхаа мөрөн дээгүүр өнгийж хараад:

- Наадхаа надад өг, бяцхан Деахорл минь – гэхэд Деахорл:

- Яагаад тэр билээ? – хэмээн гайхав.

- Яагаад гэвэл өнөөдөр миний төрсөн өдөр учир би энэ бөгжийг бэлгэнд авмаар байна

- Иш-ш чи өнөө өглөө надаас бэлэг аваа биз дээ, гомдоогүй л байх. Харин энийг бол би өөртөө зориулж олсон юм.

- Юу гэнэ ээ чи, яана гэнэ ээ чи муу бяцхан амьтан – гэж Смеахорл бувтнаад Деахорлын багалзуурт асч, багалзуурдан хөнөөгөөд бөгжийг авч хуруундаа углажээ. Үнэхээр гайхалтай сонин содон бөгж юм чинь.

Деахорлд юу тохиолдсоныг хэн ч мэдсэнгүй, гэрээсээ хол явсан, бас цогцыг нь олохооргүй булсан байв. Смеахорл гэртээ ганцаараа, үзэгдэхгүй болчихоод ирж, учир нь хамгийг захирагч бөгжийг зүүсэн эзэн мах цусан төрөлтөнд харагдахгүй болдог ажгуу. Үзэгдэхгүй болох түүнд их таалагдав, үзэгдэж харагдахгүй болчихоор юу ч хийсэн болно, тиймээс ч тэр олон хэрэг үйлджээ. Тэр бусдын яриаг далдаас сонсч, нууцыг нь харж, элдэвлэдэг болов. Бөгж түүнийг өчүүхэн муу үйлийн их хүчтэй болгож, тэр нь өөрт нь яг таарч байлаа. Төрөл садан нь түүнээс дөлж, дотно хандах амьтангүй болов. Түүнийг өшиглөхөд тэр эргүүлээд

хаздаг болжээ. Хулгай хийж дасаад, үргэлж хамар дороо нэг юм бувтнан “хорлум, хорлум, хорлум” хэмээн хоолойгоо заналтайяа хоржигнуулж явдаг болжээ. Ингээд түүнийг Хорлум гэж нэрлэх болсон ба бүгд түүнийг хөөж тууж, эмээ нь үүрэндээ оруулахаа больжээ.

Тэгээд гав ганцаараа тэнэж, бүгдийг муу муухай гэж өөртөө гомдол мэдүүлэн гонгинож, архирч, уйлагнаж явсаар уулын хүйтэн уст голд хүрээд урсгал сөрөн явжээ. Үл үзэгдэх гараараа голын загас бариад амьдаар нь иддэг байв. Нэг удаа маш халуун өдөр тогтоол ус руу тонгойтол шилэн хүзүү рүү нь халуу төөнөж, ус тэсэхийн аргагүй гялалзаж байв. Тэр ертөнцөд нар гэж юм байдгийг ор тас мартсан байжээ. Тэгээд санангуутаа нар руу нударга зангидан занав.

Тэгээд доош харахад нь Манант уул харагдаж, уулнаас нэг булаг оргилж байх үзэгдэв. Гэнэт тэр ингэж бодов: “Энэ хадан хясааны доор хичнээн сэрүүхэн, харанхуй бол. Тэнд нар над руу харахгүй. Ууланд ч гэсэн үндэс байгаа, өөрийн гэсэн нууц байгаа, тэр нууцыг зөвхөн би л мэдэх болно”.

Шөнө болоход тэр уул өөд өгсч, бараан урсгал оргилж байгаа агуй олоод чулуун гүн рүү нь өт шиг мөлхөн орж, хөрст газраас удаан хугацаагаар алга болов. Бөгж Хорлумтай хамт газар доорх харанхуй руу орсон тул тэр бөгжийг хийсэн этгээд урьд өмнөхөөсөө хамаагүй хүчтэй болсон ч гэсэн бөгжний талаар юу ч мэдэхгүй болов.

- Хүлээгээрэй, та Хорлум гэж хэлэв үү? Тэр чинь Бильботой тааралдсан амьтан байх нь ээ. Энэ бүхэн ямар муухай юм бэ – гэж Фродо дуу алдахад шидтэн:

- Миний хувьд бол муухай биш, гашуун байна, ийм явдал хоббитуудын нэгэнд тохиолдож болох байсан –гэв.

- Хорлум хоббитуудтай төрөл гэж би яагаад ч үнэмшихгүй, тийм байх ёсгүй.

- Гэвч энэ бол цэвэр үнэн, хоббитуудын гарал үүслийг би та нараас ч илүү мэднэ. Бильбогийн ярианаас үзсэн ч төрөл гэдэг нь яах аргагүй илэрхий байна. Тэр хоёр олон зүйлийн талаар адилхан бодож байсан, олон зүйлийн талаар ижилхэн санаж байсан. Бие биеэ бараг хагас үг хэлэхэд л ойлгож байсан, жишээ нь хоббит гном, орх, эльфүүдийг ойлгохоос хавьгүй амархан ойлгож байсан. Тэр хоёрын таалцсан оньсого шууд нийтлэг байсныг санаж байгаа биз дээ.

- Энэ ч үнэн шүү. Гэхдээ ганц хоббитууд л оньсого таалцдаггүй, оньсого ерөнхийдөө нийтлэг байдаг. Хоббитууд хэзээ ч луйварддаггүй, Хорлум ямагт хулгайлж, луйвардаж байдаг. Тэр эгзэг тааруулж Бильбог санаандгүй байхад нь дайрахын тулд тоглоом эхэлсэн, хожвол алж идэх амьтантай болно, хожигдлоо ч гэсэн алдах юм байхгүй.

- Тийм байх гэж айж байна. Гэхдээ бас чиний ойлгоогүй зүйл байсан. Хорлум хүртэл хамгийн адгийн шаар биш. Тэр зарим хүнээс илүү хүчтэй – тэр хоббитуудтай садан төрлийн холбоотой. Түүний оюун санаанд нэг өчүүхэн цэвэр булан үлдсэн, нарны гэрэл өчүүхэн завсраар тусах мэт тэр булан руу нь өнгөрсөн үеийн гэрэл нэвтэрч байсан. Магадгүй түүнд салхи, модод, нарны туяа гялбуулсан өвс ногоо гээд өөр олон зүйлийг санагдуулам сайхан дуу хоолой сонсох аятайхан ч байсан байж болно.

Гэвч эцсийн эцэст дийлдэшгүй хар хүч түүний дотор дахин улангассан нь мэдээж, ойр орчинд түүнийг анагаах хүч байгаагүй. Түүнд ч найдвар бага даа. Хэдийгээр тэр бөгжийг маш удаан эзэмшсэн, хэзээнээс эхэлж гэдгээ өөрөө ч санадаггүй боловч тэр бөгжийг цөөхөн удаа зүүсэн, хав харанхуй нүхэнд үзэгдэхгүй болж яах юм бэ? Тийм учраас тэр “хайлаагүй”. Тэр зомгол шиг хатмал, шөрмөслөг, тэсвэртэй. Гэвч оюун санааг нь бөгж идчихсэн учир бөгжнөөс сална гэдэг бараг тэсэх аргагүй гарз.

“Уулсын гүнзгий нууц” ёроолгүй харанхуйгаар солигдсон, мэдэж авах юм юу ч байгаагүй, амьдрах шаардлага ч байхгүй, зөвхөн хулгайгаар хоолоо олж, хуучин гомдлоо санаж, шинийг зохиохоос өөр юмгүй. Тэр харанхуйг үзэн яддаг, гэрлийг бүр ч ихээр үзэн яддаг, бүхнийг үзэн яддаг боловч бөгжийг хамгийн ихээр үзэн яддаг байсан.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? бөгж түүний “эрдэнэ” байсан, зөвхөн тэрийгээ л боддог байсан, хэрэв үзэн яддаг байсан бол хаячихна биз дээ?

- Чи зөндөө ихийг сонслоо Фродо, одоо ойлгох цаг болсон. Тэр өөрийгөө хайрлаж, үзэн яддаг байсан шигээ бөгжөө үзэн ядаж, хайрладаг байсан. Тиймээс хагацаж чаддаггүй байсан юм. Тийм сэтгэлийн хатан зориг тэрэнд байгаагүй.

Хамгийг захирагч бөгж бол Фродо минь, манаач юм шүү дээ. Бөгж өөрөө хуруунаас мултрад унаж болно, харин эзэн нь хэзээ ч хаяхгүй. Хэн нэгэнд өгч хадгалуулья гэж бодох ч үгүй. Миний л мэдэж буйгаар ганцхан Бильбо л түүнийг өөр хүнд өгөх гэж шийдээд өгсөн. Тэхдээ миний тусламжаар шүү дээ. Бильбо ч гэсэн бөгжийг орхихгүй байсан юм. Фродо минь, асуудлыг Хорлум биш бөгж өөрөө шийдсэн юм.

- Хорлумыг Бильбогоор солихоор шийдсэн хэрэг үү? Ямар нэг орх руу өнхрөөд очсон нь дээр байж дээ.

- Энэ чинь бас л жирийн хэрэг биш, үүнийг шоолдог нь чи биш. Бильбо хүрч ирээд харанхуйд санамсаргүй тэмтрээд олчихдог ямар хачин юм бэ гэж чи гайхаад байна.

Гэвч харанхуй хар хүч ертөнцийг мөнхөд захирдаггүй юм. Бөгж өөрийн эзэндээ эргэж очихыг хүссэн байна, хөөрхий Деахорл түүнийг олоод алуулсан нь дэмий хэрэг биш. Хорлум эзэмшсэн нь ч дэмий хэрэг биш. Хорлумыг жаахан сорлоо, тэгээд яах юм бэ? Хорлум өчүүхэн, хөөрхийлөлтэй амьтан. Харанхуй доторх жижиг нуураас хаашаа ч гарахгүй. Жинхэнэ эзэн хүчээ авч бөгжний араас хар бодлоо илгээхэд бөгж Хорлумыг орхижээ. Гэхдээ түүнийг орх ч биш, тролл ч биш, хүн ч биш, харин Хоббитаны Бильбо олсон. Энэ бол Дайсны хүслийн эсрэг болсон гэж би бодож байна. Бөгжийг өөр хэн нэгэн биш, Бильбо олох тавилантай байж. Энд л миний итгэлийн оч сүүмэлзээд байгаа юм.

- Надад тэгж санагдахгүй байна. Би чамайг нэг л ойлгохгүй байна. Харин чи бөгжний тухай, Хорлумын тухай яаж мэдсэнээ ярьсан нь дээр байх. Эсвэл чи юу ч мэдэхгүй, зүгээр л зохиож яриад байна уу?- гэж Фродо хэлэв. Гэндальф Фродо руу харахад нүд нь гялсхийв.

- Зарим юмыг би мэдэж байсан, зарим юмыг би олж мэдсэн, гэхдээ би өөрийнхөө бүх эрлийн талаар чамд илтгэл тавих гээгүй байна. Чиний бөгж чинь галт бичээснээс харахад хамгийг

захирагч бөгж гэдэг нь хангалттай...

- Та үүнийг хэзээ мэдсэн юм бэ?

- Чиний нүдэн дээр, зочны өрөөнд чинь – гэж шидтэн ширүүхэн хэлээд – гэхдээ би энэ нууцыг нээнэ гэдгээ мэдэж байсан. Би их урт зам туулж, их удаан хайсан – энэ бол миний сүүлчийн оролдлого байсан юм. Сүүлчийн нотолгоо энэ байна, одоо бүх юм ойлгомжтой. Учрыг олоход амаргүй байсан, юун Хорлум хаанаас гараад ирсэн, эртний цуст түүхтэй яагаад орооцолдсон гээд л. Хэрэг явдал хэрхэн өрнөснийг би одоо мэдэж байна. Би тэрнийг харсан.

- Та Хорлумыг харсан гэж үү?

- Тийм ээ, харсан. Түүнгүйгээр учрыг олох боломжгүй гэдэг ойлгомжтойгоос ойлгомжтой. Гэвч түүнтэй ярина гэдэг бараг боломжгүй зүйл байсан даа.

- Бильбогоос хойш тэр яасан бол? Та мэдэж байна уу?

- Тун ч бүрхэг. Миний чамд ярьсан зүйл бол Хорлумын ярианаас авсан зүйл, гэхдээ тэр яг ингэж яриагүй л дээ. Тэр бол агуу худалч учир хэлсэн үг бүрийг нь шүүн тунгаах хэрэгтэй байсан. Жишээ нь бөгжийг түүнд эмээ нь төрсөн өдрөөр нь бэлэглэсэн, эмгэнд ийм зүйлс зөндөө байсан гэх мэт.

Хорлум Деахорлыг алснаа мартаж чадахгүй байсан, тиймээс өөрийнхөө ой ухаантай бүх чадлаараа тэмцдэг байсан. Харанхуйд хар яс хэмлэж, өөрийн “эрдэнэ”-дээ нэг л худал үгийг давган хэлсээр байгаад сүүлдээ өөрөө бараг итгэчихсэн юм билээ. Миний төрсөн өдөр болсон, Деахорл надад бэлэг өгөх ёстой байсан, энэ бол төрсөн өдрийн хамгийн гоё бэлэг гэх мэтчилэн.

Би тэрний авцалдаагүй худал чалчихыг тэвчээд л байсан, гэвч ямар ч үнээр хамаагүй үнэнийг мэдэх хэрэгтэй байсан тул би хатуу арга хэмжээ авч галаар айлгасан чинь тэр үнэнийг бага багаар, нус нулимсандаа хахаж цацан байж ярьсан. Тэрнийг гомдоож, доромжилж дээр нь нэмээд дээрэмдсэн юм байх аа. Би тэрнээс оньсого, Бильбо зугтаасан тухай бүгдийг яриулж чадсан боловч цаашаа тэр хэлгүй болчихоод хааяа нэг бүдэг бадаг юм бувгнаад байсан. Ямар нэг айдас тэрний хэлийг гацаагаад байх шиг байсан тул би яаж ч чадаагүй. Би хэнд ч бууж өгөхгүй, намайг хөөж, хуурч, дээрэмдэх ямар байдгийг үзүүлээд өгнө ч гэх шиг. Надад гайхамшигтай сайн найз нар байгаа, орхууд өвөлждөг газарт байгаа миний найзууд надад тусална, хулгайч Торбинс төлөөсөө төлнө, үйл тамаа үзнэ ч гэх шиг. Бильбог аймшигтайгаар үзэн ядаж, харааж зүхэж байсан. Гэвч хамгийн аюултай нь тэр Бильбо гэж хэн бэ, хаанаас ирсэн бэ гэдгийг мэднэ.

- Хэн тэрэнд хэлдэг байна аа?- гэж Фродо сандрав.

- Бильбо өөрийгөө танилцуулж тэнэглэсэн байгаа юм, дараа нь дээшээ мөлхөж гардаг л юм бол хаанаас ирснийг мэдэхэд юухан байх вэ дээ, Хорлум мөлхөөд гарсан. Бөгжөө тэсвэрлэшгүй ихээр санаж байсан, бөгжөө санахын дэргэд орхуудаас айх, нарны гэрлээс айх юу ч биш. Бөгж түүнийг нэг хоёр жил тарчлаагаад дараа нь арай гайгүй болсон тул тэр бага

зэрэг сэргэсэн. Хөгшрөлт дарамттай байсан ч мөнхийн айдас болгоомжлол алга болсон, тэгээд ч үхтлээ өлсдөг байсан юм чинь.

Нарны ч бай, сарны ч бай гэрэл түүнд тэсэхийн аргагүй дайсан байсан, эцсийн өдрөө хүртэл тийм байх биз, гэвч ов заль, гавшгай шаламгай нь дэндүү. Нар сарны гэрлээс нуугдаж болно гэж ухаарсан, харанхуй шөнөөр хурдан бөгөөд чимээгүй явж болно гэж мэдсэн, харанхуйд жижиг амьтдыг барьж идсээр хүчтэй, зоригтой болсон. Балар шугуй хүртэл холгүй, тэнд яваад хүрчихсэн.

- Та түүнийг тэндээс олсон уу?

- Би түүнийг тэнд харсан. Гэхдээ тэр тэнд шууд очоогүй, Бильбогийн мөрийг мөшгөсөн байгаа юм. Дараа нь юу болсныг мэдэхгүй. Харааж, зангаад л нэг юм үглээд байсан. ”Тэрний халаасанд юу байсан бэ? Миний эрдэнэ байсныг би мэдсэнгүй. Муу хорт могой. Шударга биш оньсого байсан. Тэр намайг луйвардсан, тэр дор нь багалзуурдаж алах байсан юм. Гэхдээ яах вэ, багалзуурдах цаг ирнэ гээд л эцэс төгсгөлгүй үглээд байсан.

Би олон хоног үүнийг өглөөнөөс орой болтол тэвчиж байсан. Тэгснийхээ ачаар бага сага хэсэг бусаг юм мэдэж авсан. Тэр Эсгарот хүрч, хотын гудамжинд яриа чагнаж байж. Бүгд л Бильбогийн тухай үлгэр домог шиг юм яриад байсан юм билээ. Сонор чихтэй Хорлум бүгдийг сонсоод юу хийхээ ойлгожээ.

- Тэр яагаад Бильбог эцэслэн мөрдөөгүй юм бол? Эсвэл Хоббитанд ирээд буцсан юм болов уу?

- Ирээгүйд л хамаг учир байгаа юм. Наашаа ирж явсан. Их мөрөн хүрээд гэнэт эргэсэн байгаа юм. Тэр алсын замаас айхгүй. Ямар нэг далдын хүч л түүнийг будлиулсан. Надад түүнийг барьж өгсөн найз нар маань ч тэгж бодож байгаа юм. Тэрний шинэхэн мөрийг эльфүүд олсон ч өөрийг нь барьж чадаагүй. Балар шугуйн баруун захаас гэдрэг эргэж, өмнө зүг явж ойгоос гараад мөр нь алдагдсан. Тэгэхэд би маш том алдаа гаргасан. Анхных биш боловч хамгийн аюултай алдаа. Би түүнийг дуртай зүг рүүгээ яваг гээд зөнд нь орхичихсон юм. Надад яаралтай ажил их байсан, тэгээд ч Саруманы мэргэн ухаанд найдсан юм.

Түүнээс хойш хагас зуун жил өнгөрөхөд би тэр алдаагаа хүнд хар өдрүүдээр төлсөн. Бильбог явсны дараа надад Хорлум зайлшгүй хэрэгтэй болохыг ойлгоход тэрний мөр аль эрт алдагдсан байлаа. Би тэрнийг хайж олох найдваргүй байсан ч миний үнэнч найз, өнөө үеийн шилдэг мөрдөгч, анчин Арагорн намайг аварсан билээ. Бид хоёр олно гэсэн найдваргүй мөртөө зэлүүд бөглүүд газрыг нэгд нэггүй самнасан. Цөхөрч гүйцээд би эрлээ зогсоохоор шийдтэл Хорлум гэнэт олдсон. Найз минь үхлийн аюултай аяллаас золоор эргэж ирэхдээ Хорлумыг чирээд ирсэн.

Хорлум хаагуур алга болж яваад олдсон нь нууц хэвээрээ үлдсэн. Тэр бас л нус нулимсандаа хахаж цацаад л, биднийг харгис хэрцгийгээр минь дуудаад л хоолой нь “хорррлум, хоррлум” гээд л хоржигноод байсан. Ямар сайндаа л тэгж нэрлэв гэж. Галаар айлгахад ч атирч матираад л, эхэр татаад л, чөргөр урт хар гараа мушгиад л, түлэгдсэн юм шиг хуруугаа долоогоод л байсан. Тэр юу ч хэлээгүй боловч, удаанаар, алхам алхмаар, сэмхэн өмнө зүг

явсаар Мордорт очсон нь эргэлзээгүй.

Тасалгаа аймаар нам гүмд умбаж, Фродо зүрх нь хэрхэн тонгочиж байгааг сонсч байлаа. Гадаа ч гэсэн бүх юм нам жим болж, Сэмийн хайч ч чимээгүй болжээ.

- Тийм ээ, Мордорт очсон нь гарцаагүй, тэнд хамаг хар хор үүрлэдэг, хар муу үйлтнүүдийг Бөгжний Эзэн тийш нь дууддаг юм. Бөгж Хорлумын ухааныг идсэн болохоор тэр далдын хүчний тасралтгүй дуудлагаар явсан байж таарна. Тэнд л тэрний жинхэнэ найз нар нь байсан, тэд л өшөөгөө авахад нь тусална гэж Хорлум бодсон байж таарна.

Азгүй тэнэг! Тэр Мордорын хил орчмоор удтал тэнэж байгаад баригдаж байцаагдсан байна. Тэр тэнд маш удаан байсны хойно нааш гарч явахад нь Арагорн тэрнийг барьсан. Нэг бол тэрэнд даалгавар өгч явуулсан, эсвэл өөрөө нэг аймаар муухай юм хийхээр шийдсэн хэрэг. Гэхдээ энэ чухал биш, тэрний учруулах гол аюул нэгэнт өнгөрсөн.

Тийм боловч хохирол нь их. Дайсан хамгийг захирагч бөгж олдсоныг Хорлумаас мэдэж авсан, Хорлум бөгжийг хаанаас олсон нь тодорхой болсон, энэ бол төгсгөлгүй амьдрал бэлэглэгч агуу бөгж, энэ бол эльфүүдэд байгаа гурван бөгжний нэг биш гэдэг нь ойлгомжтой, эльфүүд хадгалж байсан болохоор тэр бөгжнүүд цэвэр, энэ бол яг өнөөх бөгж гэдгийг Дайсан ойлгосон, дээрээс нь тэр хоббитууд, Хоббитан орны тухай мэддэг болсон.

Тэр одоо бөгжийг хайж байгаа нь мэдээж, тэгээд ч танай ураг удмын нэр Дайсанд илэрхий болсон гэдгийг мэд Фродо.

- Энэ чинь аймшигтай шүү дээ. Аймшгийн аймшиг шүү дээ – гэж Фродо хашгираад Гэндальф минь, итгэлт найз минь, би одоо яах вэ, хэлээд өг. Одоо би яах вэ? Тийм аятайхан боломж байсаар атал Бильбо тэр новшийг өрөвдөөд алаагүй гэж юу гэсэн үг вэ?

- Өрөвдөөд гэв үү? Тиймээ өрөвдөөд, буяныг бодоод алаагүй юм. Үүний төлөө Бильбо багагүй шан авсан. Тэр харанхуй хар хүчний зарц болоогүй, аюул дундаас амьд гарсан. Яагаад гэвэл өрөвч сэтгэлийн шан.

- Уучлаарай, энэ тухай яриагүй байна, айдас намайг хүлж байна, Хорлумыг өрөвдөнө гэдэг байж болшгүй зүйл. Эльфүүд, та, өөр бас хэн ч байдаг юм, тийм муухай хэрэг хийсэн тэр амьтныг өршөөж байгаа юм бэ? Тэр үхэх шалтгаанаа өөрөө хийсэн.

- Тийм ээ, маргах юм алга. Гэхдээ цаазлах гэж бүү яар. Мэргэд хүртэл бүхнийг урьдаас мэддэггүй. Хорлум засарна гэсэн найдвар тун бага. Гэхдээ хэн Хорлум ерөөсөө байхгүй гэж хэлж чадах юм бэ? Тэрний хувь заяа бөгжнийхтэй нэгдсэн. Тэр одоо сайны ёр уу, муугийн ёр уу, ямар ч байсан хэрэг болно гэж миний зүрх мэдрээд байна. Зангилаа тайлагдах цагт Бильбогийн өрөвч сэтгэл олон хоббитын, тухайлбал чиний авралын баталгаа болж магадгүй юм шүү. Бид тэрнийг өршөөсөн: тэр хөгшин, арчаагүй амьтан, тийм амьтныг цаазалдаггүй. Тэр ойн эльфүүдийн дунд хоригдож байгаа, тэрэнтэй сайнаар харьцаж байгаа гэдэгт би итгэлтэй байна.

- Яасан ч ялгаагүй, Хорлумыгаа алдаггүй юм гэхэд тэр бөгжийг Бильбо яах гэж авсан юм бэ?

Гол нь яах гэж надад өгч байгаа юм бэ? Би энд ямар хамаатай юм бэ? Яагаад чи надаас аваагүй юм бэ, яагаад устгуулаагүй, хөсөр хаяулаагүй юм бэ?

- Хөсөр хаяна гэнэ ээ? Чи миний үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөгөөд байна уу? Ярихаасаа өмнө бод. Усан тэнэг л тэр бөгжийг хаяна. Шидэт бөгжнүүд алга болдоггүй юм. Хэн ч оллоо гэсэн энэ ертөнцөд байх л болно. Бөгж дайсны гарт орж болно, ер нь заавал орно, тэр асар хүчтэй хүчир чармайлтаар өөр рүүгээ татаж байгаа.

Фродо эрхэм минь, чи их аюулд ороод байна, тиймээс л би санаа зовж байгаа юм. Одоо байдал ямар болоод байна гэвэл хамгийн гол нь дэнчин тавьж болохгүй, чамаар ч дэнчин тавьж болохгүй, намайг энд байхгүй байхад чи нүд салгахгүй хараа хяналтад байсан гэдгийг мэдэж ав. Чи бөгжийг нэг ч удаа зүүгээгүй гэж би мэдэж байна, тэгэхээр бөгж чамайг боловсруулаагүй. Одоохондоо шүү дээ. .. Есөн жилийн өмнө бид хоёр сүүлчийн удаа уулзахад би юу ч мэдэхгүй байсан юм.

- За яахав, хаяж болдоггүй юм байж, гэхдээ устгаж болно, та өөрөө аль эрт устгах хэрэгтэй байсан юм гэж хэлж байсан шүү дээ, надад анхааруулсан бол би энэнээс салах л байсан.

- Салах байсан гэж үү? Яаж? Чи оролдож үзсэн юм уу?

- Үгүй л дээ, гэхдээ яаж ийгээд хавтгайлах юм уу хайлж болно биз дээ?

- Тэгвэл оролдоод үз л дээ.

Фродо бөгжийг халааснаас гаргаж ирээд харав. Бөгж цэвэрхэн гилгэр, ямар ч бичээсгүй байв. Алтны өнгө хурцаар туяарч, Фродо ямар сайхан цутгасан юм бэ, ямар ч уран хийсэн юм бэ гэж бодов. Тэр бөгжийг гал руу шидэх гэсэн боловч чадахгүй юм байна гэдгээ ойлгов. Тэр бөгжийг алган дээрээ тавьж, Гэндальфын аймшигт яриаг бодож байснаа гэнэт бөгжийг халаас руугаа яаран хийж байгаагаа анзаарав.

Гэндальф урам муутайхан инээлээ:

- За харж байна уу? Фродо чи хүртэл бөгжнөөс салж чадахгүй байна шүү дээ. Бөгжийг ямар ч хүчээр устгаж болохгүй. Жаран футын дархны лантуугаар хичнээн балбасан ч зураас гарахгүй. Би яаж ч чадахгүй байхад чи яах ч билээ.

Чиний энэ галд ердийн алт ч хайлахгүй. Бөгж энэ галд хайлах нь байтугай өнгө орж, халах ч үгүй байсныг чи хараа биз дээ. Чиний Хоббитан оронд энэ бөгжний хэлбэрийг өчүүхэн төдий өөрчилж чадах нэг ч дархан байхгүй. Гномуудын хөөрөг, лантуу ч яаж ч чадахгүй. Шидэт бөгжнүүд лууны галд хайлна гэдэг л байсан, гэвч өнөөгийн луунууд агуу Саурон өөрөө давтсан агуу бөгжийг хайлах чадал байхгүй.

Ганцхан л арга бий. Үнэхээр чи энэ бөгжийг үүрд хайлж, Дайсны гарт орохгүй байхыг хүсч байгаа бол Үхлийн уулан дахь зэвсгийн балгасанд хүрч, цогшиж байгаа гал руу шидэх хэрэгтэй.

- Би ч хүсч л байна л даа. Гэвч би биш, өөр хэн нэгэн хаяна биз, надад ийм гавьяа байгуулах хүч чадал байхгүй. Ер нь би энэнд ямар хамаатай юм бэ?

- Асуулт асуултандаа, чамд ямар хариулт хэрэгтэй юм бэ? Гавьяа байгуулуулах гэж чамайг сонгосон гэж үү? Чамд тийм хүч чадал ч байхгүй, ухаан ч байхгүй. Гэвч чамайг аль хэдийн сонгосон, тэгэхээр чи тийм хүчтэй, ухаантай, эр зоригтой болох хэрэгтэй.

- Би яаж чадах юм бэ? Гэндалф чи хүчтэй, мэргэн ухаантай. Май энэ бөгжийг ав.

- Үгүй шүү, - гэж хашгираад Гэндалф арагш ухарч, нүд нь гялалзан нүүр нь дотроосоо галаар гэрэлтэж – надад тийм хүч байх юм бол би бөгжний хамгийг чадагч боол болно. Энэ миний ажил биш, Хар эзэн аймшигтай - би түүнээс ч аймшигтай болно. Бөгж миний зүрхэнд хүрэх замаа мэднэ, би сул дорой амьтан бүгдийг энэрч хайрладгийг мэднэ, би бөгжний тусламжаар тэднийг ямар их найдвартай хамгаалж чадна гээ, дараа нь би тэднийг өөрийн боолоо болгоно. Би бөгж хадгалагч болохгүй, тэгвэл миний өмнө харанхуй, үхэл хоёр л харагдах болно.

Гэндалф цонх руу очоод хөшиг нээхэд тасалгаанд дахиад нарны гэрэл цацарлаа. Цонхны хажуугаар Сэм исгэрэн алхаж өнгөрөв.

- Чи л шийдэх хэрэгтэйг харж байгаа биз дээ. Би чамайг орхихгүй – гээд шидтэн Фродогийн мөрөн дээр гараа тавьж – энэ ачааг чи үүрч байгаа цагт би чамд тусална. Зөвхөн түргэлэх л хэрэгтэй байна. Дайсан яарч байгаа – гэв.

Дахиад чимээгүй болж, Гэндалф зөөлөн сандалд суугаад тамхиа сорон бодол болов. Нүдээ аньсан боловч зовхиныхоо дороос Фродог анхааралтай ширтэж байлаа. Фродо задгай зуухан дахь хүрэн улаан цог руу нүд салгалгүй ширтэх бөгөөд өөр юу ч нүдэнд нь харагдахгүй, галт худаг руу өнгийж байгаа мэт санагдана. Тэрбээр эртний аймшигт уулын хүрэн улаан тогооны тухай бодож байв.

- За юуг сэтгэж байна даа, ямар шийдвэр гарав? – гэж Гэндалф асуув.

- Ямар ч биш ээ – гэж Фродо аяархан хэлээд галын тухай бодохоо больж, гэрэл дүүрэн тасалгаа, хурц гэрэлтэй цонх, нарлаг цэцэрлэгийг гайхан харж – ер нь шийдчихлээ. Таны ярьсныг бүгдийг нь ойлгохгүй байгаа боловч одоохондоо бөгжийг өөртөө байлгаж хамгаалах хэрэгтэй юм шиг байна, юу л болбол болог – гэв.

- Чамд олон юм тохиолдож болно, гэхдээ эхлэл чинь муугүй байна. Бөгж одоохондоо муу юм руу түлхэхгүй.

- Энийг та л мэднэ, харин арай найдвартай хадгалагч олбол сайн сан даа. Одоохондоо чиний зөв юм бол би их аюулд ороод байна. Найзууд маань ч ялгаагүй. Би гэртээ байх юм бол бөгжийг болон найз нараа хамгаалж чадахгүй байх. Тэгэхлээр Уутан хясаагаа ч, Хоббитанаа ч орхиж, харсан зүгтээ явах л үлдэх шив дээ – гээд Фродо санаа алдаж – Хоббитанд минь л бүх юм хуучин хэвээрээ байгаасай даа, би заримдаа хоббитуудыг тэнэг мангуу гэж харааж зүхэн, газар хөдлөөсэй, луунууд ирээсэй гэж дууддаг байсан, одоо тэр үгээсээ буцаж байна.

Ард минь Хоббитан байгаа цагт надад амар байх болно. Ухрах газар байхгүй ч гэсэн ухрах газартай гэж бодож явъя.

Мэдээж би урьд нь алсын замд гаръя гэж бодож л байсан, гэхдээ аяллыг Бильбогийнх шиг адал явдал, зугаалга гэх мэтийн сонирхолтой, тэгээд бас азтай сайхан төгсгөлтэйгээр төсөөлж байсан. Харин одоо бол айдсаас айдаст, араас үхэл нэхсэн аялалд гарч байна. Аялахдаа би ганцаараа аялна, нэгэнт надад Хоббитаныг аврах хувь тохиосон бол өөр яах билээ. Би жижиг, тэдний хувьд харийн, юу ч гэмээр юм, хүний газрынх. Гэтэл Дайсан аварга их хүчтэй, аюумшигтай гэж Фродо ярив.

Тэр ингэж ярьж байхдаа Бильбогийн араас явах хүсэл оргилж, бүр уулзаж ч магадгүй гэж бодож байснаа Гэндальфт хэлсэнгүй. Түүний энэ хүсэл маш хүчтэй байсан учир айдсыг давж, Бильбо шиг малгай ч үгүй, зүгээр л гараад гүйчихмээр байлаа.

- Энэ чинь чи мөн үү Фродо? – гэж Гэндальф дуу алдаад – хоббитууд гайхамшигтай амьтад гэж би урьд үнэн хэлжээ. Тэднийг судлахад нэг сар хангалттай мэт боловч зуун жилийн дараа алмайртал гайхуулах юм гээч. Ийм юм болно гэж бодсонгүй шүү. Бильбо ямар чухал болохыг нь мэдээгүй мөртөө залгамжлагчаа сонгохдоо алдсангүй. Чи дээд зэргийн зөв шийдвэр гаргах шиг боллоо. Өнөө цагт бөгж Хоббитанд байх газаргүй, чи алс замд гарч нэг хэсэгтээ Торбинс гэдгээ мартаж хэрэгтэй боллоо. Ганц чи ч биш. Энэ бол Хоббитаниас өөр газарт аюултай нэр. Эрчилс гэдэг нэр зүгээр юм шиг байна.

Ямар ч гэсэн чи ганцаараа явахгүй. Чи найз нарынхаа хэнд нь илүү итгэдэг вэ, үхэлтэй сөрөн тулах үед хэн нь тэсч гарах чадвартай вэ? Тийм найз нөхөр байхгүй ч гэсэн дагуулж явах хүн сонго, чамд маш их хэрэг болно. Бага чалч, хамгийн дотнын нөхөртөө ч гэсэн хамаг юмаа дэлгэх хэрэггүй. Дайсан энд тэндгүй тагнуул туршуултай, ярьсан бүхнийг чинь сонсоно шүү.

Шидтэн гэнэт дуугүй болж чимээ чагнав. Тасалгаанд ч, цэцэрлэгт ч нам гүм. Гэндальф цонх руу гэтэж очоод, тавцан дээр үсрэн гарангуут урт гараа сунгаж Сэм Скромбийн буржгар толгойг чихнээс нь татан гаргаж ирэв.

- Өө за за, сахлаараа тангараглая, Сэм Скромби өөрийн биеэр, цонхон дор байгаа юм биз дээ?

- Та юу хэлнэ вэ ноёнтоон, яалаа гэж дээ ноён Гэндальф, юуны чинь цонх вэ, би зүгээр л зүлэг усалж, тайрч байсан шүү дээ, харахгүй юу – гээд хайчаа үзүүлэв.

- Харж байна аа, харин хайч чинь дуугарахаа болиод их удаж байна шүү. Чагнаж байгаа юм биз дээ?

- Чагнах гэнэ ээ? Яалаа гэж дээ эрхэм дээдэс ээ, хамаг зүлэг хатаад байна шүү дээ.

- Чи битгий тэнэгтээд бай! Юу сонссон бэ? Яах гэж чагнасан бэ – гээд Гэндальфын хөмсөг гялсхийж, хууз сахал нь босоод ирэв.

- Ноён Фродо ядаж та – ядаж та намайг хамгаалаач - гэж Сэм айсандаа ухаан алдах шахан

хашгираад – намайг нүд ирмэх зуур л юу ч юм болгочихно шүү дээ. Дараа нь тэгээд миний өвгөн эзэнд намайг гэж яаж үнэмшүүлэх юм бэ? Би ямар ч муу юм хийхийг хүсээгүй, нээрэн шүү ноёнтоон

- Чамайг юу ч болгож хувиргахгүй – гэж гайхсан, зэвүүцсэн Фродо инээдээ барьж ядан хэлээд
- Чи муу санаагүй сонсч байсныг чинь бид хоёр мэдэж байна, чи айх хэрэггүй, харин асуултад хариул! –гэхэд:

- Тиймээ ноёнтоон, би аль байдгаараа л чагнасан боловч бүгдийг нь ойлгоогүй: Дайсны тухай, бөгжний тухай, бас ноён Бильбогийн тухай, бас луунууд, Галын уул, мэдээж эльфүүд. Чагнаа гэж чагнаагүй юм, санамсаргүй юм болдог шүү дээ. Надад хоол битгий өг, харин эльфүүдийн тухай чагнах боломж өгөөч. Тэд юу ярих нь хамаагүй, өрөөсөн нүдээрээ ч хамаагүй тэднийг нэг харах юмсан. Эрхэм дээдэс та явах юм бол надад эльфүүдийг харуулж өгөөч!

Гэндальф гэнэт тачигнатал инээж:

- Наашаа ороод ир! – гээд Сэмийг хайч, хүртэй нь цонхоор сэвхийтэл татан оруулж шалан дээр тавиад – Эльфүүдийг харуулаад өг гэв үү чи? – гэж асуунгаа Сэм рүү хараад өөрийн эрхгүй инээмсэглэн:

- Эзэн чинь хол явах гэж байгааг сонсов уу чи?

- Сонсолгүй яхав, сонсонгуутаа найтаачихсан, тэгээд танд мэдэгдчихлээ л дээ. Санамсаргүй шүү, надад их хэцүү байна.

- Яах ч арга алга даа Сэм –гэж Фродо гунигтай хэлэв. Тэр Хоббитан орноос явахад маш хүнд, ганц Ууган хясааг орхиж байгаа биш болохоо гэнэт ойлголоо.

- За миний явах цаг боллоо. Харин чи – гээд Фродо Сэм рүү ширүүн харж - үнэхээр миний төлөө санаа зовж байгаа юм бол амаа сайн хамхиарай, за юу! Санамсаргүй сонссон зүйлээсээ нэгийг л чалчих юм бол Гэндальф чамайг толбот бах мэлхий болгож орхино. Хорт могойнууд муусайн мэлхийнүүдтэй хатуу тоглодгийг мэднэ биз дээ?

Сэм чичирч өвдөг сөхрөн унав.

- Бос Сэм! – гэж Гэндальф тушаагаад – Би бүр ч аймшигтай юм бодож оллоо. Чи юуны ч тухай чалчиж чадахгүй, яриа чагнах ямар аюултайг мэдэж авах болно. Чи Фродотой явна!

- Би юу? Эзэнтэй юу? – гэж сэм дуу алдаад, гадуур зугаалуулахаар дуудсан нохой шиг үсрэн босоод – Бас эльфүүд болоод өөр олон юм үзэх юм уу? Урраа! – хэмээн хашгирснаа гэнэт цурхиртал уйлах нь тэр.

Бүлэг 3

Аян замд гурвуулаа

Чив чимээгүй, аль болохоор түргэн гарах хэрэгтэй– гэж Гэндальф байнга яаруулна.

Эхний яриа болсноос хойш гурван долоо хоног өнгөрчихөөд байхад Фродо замд гарахаар завдаагүй л байв.

- Мэдэж байна аа. Түргэн бөгөөд чимээгүй гэдэг чинь амархан юм биш байна. Би Бильбо шиг л гараад явчихна, Хоббитан даяар дуулиан болно.

- Үгүй ээ, чи Бильбо шиг гарч хэрэггүй. Тэгэх л бидэнд дугааж гэнэ! Хурдан, гэхдээ гэнэтхэн биш. Хоббитаныг илүү шуугиангүйгээр орхихыг бод, ямар ч гэсэн түргэл, цаг алдаж л болохгүй юмсан.

- Намар, бид хоёрын төрсөн өдрийн дараа гардаг ч юм билүү, тэр болтол би бүгдийг зохицуулчихна – гэж Фродо хэлэв.

Үнэнийг хэлэхэд, яг явахаа болоод ирэхэд түүний аян замд гарах сонирхол ор тас алга болсон байв. Түүний хувьд Ууган хясаа гэнэтхэн үгээр илэрхийлэхийн аргагүй тав тухтай болж, Хоббитанд өнгөрөөх сүүлчийн зунаар сэтгэлийн цэнгэл эдэлж байлаа. “Намар болохоор манай энд уйтгартай болно, тэгэхлээр зүрх минь урьдын адил харийн газар аялахыг хүсэх болно” гэж тэр бодож байв. Дотроо тэр өөрийн тавин нас, Бильбогийн нэг зуун хорин найман насны ойг хийхээр хатуу шийдсэн байв. Бильбогийн жишээгээр ойгоо тэмдэглэхийнхээд л аян замд гаръя. Түүний үлгэр дуурайлгүйгээр нэг ч алхам хийхгүй, амьдралдаа нэг ч шийдвэр гаргахгүйсэн билээ. Аяллын зорилгын талаар бодохоо ч больж, Гэндальфтай ч илэн далангүй ярихгүй байлаа. Шидтэн үүнийг таамаглаж байсан боловч хүлээцтэй зангаараа дуугүй л байв.

- Бүгдийг зохицуулна, тэгээд хөдөлнө өө - гэж Фродо улигт үгээ давтахад Гэндальф түүн рүү хараад жуумалзсанаа:

- За яахав тийм байж, оройтохгүй л юмсан. Надад нэг л хачин түгшүүртэй байна. Харин хаашаа явах талаараа хэнд ч нэг ч үг цухуйлгаж болохгүй шүү. Тэр Сэм чинь ч үхсэн юм шиг дуугүй байх хэрэгтэй, тэгэхгүй бол ёстой миний өмнө мэлхий болж дэвхэрнэ.

- Хаашаа явахаа би өөрөө ч мэдэхгүй байгаа юм чинь юугаа хэлэх вэ дээ

- Тэнэглэхээ боль, чамайг хаашаа явсан нь бүү мэд алга болох тухай би яриагүй. Гэвч чи Хоббитаныг орхиход хэн ч мэдэх ёсгүй. Харин баруун зүүн, хойш урагш аль зүг явахаа л нууцлах хэрэгтэй.

- Ууган хясааг орхиж, бүгдтэй салах ёс хийх надад маш гунигтай байна, тэгэхээр хаашаа явах тухай бодоогүй, ер нь тэгээд хаашаа явах юм бэ, хаана нуугдаж болохыг би яаж мэдэх юм бэ?

Бильбо эрдэнэс олохоор явсан, олоод эргэж ирсэн, би яах юм бэ? Эрдэнэсийг эргүүлж өгөөд өөрөө үхэж далд орох юм уу?

- Тэр нь ч юу юм бэ? Би энэ талаар чамд хэлэх юм алга. Магадгүй чи Зэвсгийн балгас орох юм уу, эсвэл энэ огт чиний хийх ажил биш юм уу, би яаж мэдэх вэ? Би өөр л юм мэдэж байна: чи ийм аянд хараахан бэлэн биш байна.

- Өө тийм бий? Тэгвэл би хаашаа явах юм бэ?

- Алс хязгаар руу. Алсын алс хязгаарт тууштай бөгөөд болгоомжтой. Чи ерөөсөө Уудам хөндий яв! Энэ бол хэтэрхий аюултай зам биш, гэхдээ замд одоо тайван биш байгаа, намар бүр ч түгшүүртэй болно.

- Уудам хөндий гэнэ ээ? Тэгье, дорно зүг Уудам хөндий рүү явъя. Сэм надтай хамт явна, эльфүүдийг үзэж ханатлаа баярлаг.

Тэр энэ үгийг зүгээр л нэг хэлсэн боловч Гайхалтай омгийнхон энх амар аж төрсөөр байгаа тэр баян хөндийд очиж үзэхийг туйлаас хүсэв.

Зуны нэг үдэш “Ногоон луу”-ны “Дархан булан”-д цугларагсад хил дээр аваргууд болон бусад бузар амьтад үзэгдсэн тухай, Фродо Уутан хясааг худалдаж байгаа ч юм уу, худалдчихсан тухай жигтэй хачин мэдээлэл хэлэлцэв. Хэнд худалдах гэж? Лякошел-Торбинсуудад.

- Мэдээж их мөнгөөр зарсан даа – гэж зарим нь ярина.

- Өөрийнх нь үнээр л зарсан, Любели сохор зоос ч илүү өгөхгүй (Оддо зуун хоёр наслаад, мөрөөдлөө биелэхийг үзэлгүй нас барж амжжээ) - гэж зарим нь ярина.

Үнийн талаар удаан маргалдсан боловч яагаад Фродо тийм сайхан эдлэнгээ худалдах болсон талаар илүү их маргалдав. Зарим нь ноён Торбинс мөнгөө барж байгаа, Норгордод тооцоогоо дуусгаад Зайгордод садан төрлүүд рүүгээ нүүж очиход л дөнгөн данган хүрэлцэнэ, ноён Торбинс өөрөө иймэрхүү үг цухуйлгасан гэцгээнэ.

- Лякошелийнхнээс холдож л байвал болох нь тэр – гэж зарим нь үг хавчуулна.

Бүгдээрээ л Бильбогийн барагдашгүй их баялгийн тухай ярианд дассан болохоор дассан юмнаасаа салах хэцүү учир ихэнх нь үүнд Гэндалфийг буруутгаж байв.

Бараа нь ч харагдахгүй, сураг нь ч сонсдохгүй баймаар атал тэр одоо Фродогийнд сууж, Уутан хясаанд нуугдаж байна. Фродо Зайгорд руу нүүх нь шидтэнд ямар хэрэгтэй нь ойлгомжгүй байна, ямар ч гэсэн хэрэгтэй л байж таарах нь гэцгээв.

- Намар нүүнэ. Мерри Дэндүүдэлдэн надад тэнд цэвэрхэн үүр олж өгнө, тохилог байшин ч олоод өгч магадгүй гэж Фродо нотолжээ. Мерри үнэхээр Зайгордоос холгүйхэн орших Молтогчингийн судагт тун аятайхан жижиг байшин худалдаж авсан байна. Фродо Сэмээс бусад бүх хоббитуудад тийшээ нүүх тухайгаа ярьжээ. Дорно зүг аялах төлөвлөгөө түүнд энэ санааг хэлж өгсөн бололтой: Туулайн толгод замд байгаа. Багадаа тэнд амьдарч байсан юм

чинь яагаад тийшээ нүүж болохгүй байх билээ?

Гэндальф Хоббитанд хоёр сар гаруй байсны дараа зургадугаар сарын сүүлээр нэг орой, Фродогийн төлөвлөгөө боловсорч байх үес гэнэтхэн маргааш өглөө явлаа гэж мэдэгдэв.

- Нэг их удахгүй байх гэж найдаж байна. өмнөдөд надад бага сага ажил байна. Тэгээд ч танайд удаан суучихлаа гэж тэр хэлэв. Тэр тун энгийн байдлаар ингэж хэлсэн боловч сэтгэл нь ихэд түгшсэн шинжтэй байх шиг Фродод санагдав.

- Ямар нэг юм болоо юу?

- Одоохондоо үгүй дээ, гэвч надад түгшүүртэй, хэтэрхий ойлгомжгүй мэдээ ирлээ, учрыг нь олох хэрэгтэй байна. тэгээд л эргээд ирнэ, үгүй гэхэд мэдээ өгнө. Чи төлөвлөснөөрөө ажилла, маш болгоомжтой байгаарай, бөгжийг бүхнээс илүү хамгаалаарай. Битгий л зүүгээрэй. Хэзээ ирэхээ сайн мэдэхгүй байна. Гэхдээ чамайг замд гарахаас өмнө заавал амжина. Ямар ч гэсэн чамайг Их замаар газарчлах хэрэгтэй болох байх гэж тэр үүрээр гарахдаа хэлэв.

Фродо эхлээд Гэндальфаас ямар мэдээ авах бол гэж санаа зовж байснаа дараа нь тайвшрав. Үнэхээр сайхан цаг агаар байсан юм чинь. Зун өргөн дэлгэр, өнөр баян болж, намар нь хоббитууд аль эртнээс үзээгүй өндөр ургацтай байлаа. Моддын мөчир жимсээ даахгүй хугарч, цэцэгс балаар ундарч, тариа буудай өтгөн түрүүгээ тэнгэрт өргөн байлаа.

Гэвч намар хаяанд тулаад ирэхэд Фродо тоглоом ч үгүй санаа зовж эхлэв. Есдүгээр сар дундаа орчихоод байхад Гэндальф усанд унасан юм шиг таг чиг. Насны ой, аянд гарах хамарт тулчихаад байхад түүний бараа сураг ч байдаггүй. Энэ хооронд нүүдлийн ажил ундарлаа. Фродогийн найзууд: Фредегар Минж, Фолко Талх, мэдээж хэрэг Ногоон Молтогчин, Мерри Дэндүүдэлдэн нар нүүдэлд бэлтгэж, ачаа бараа баглаж бооход тусаллаа. Тэд нарын нийтийн чармайлтаар Ууган Хясааны эдлэн орвонгоороо эргэв.

Есдүгээр сарын 20-нд Фродогийн өргөөнөөс Брендидуимын гүүр рүү худалдаагүй эд хогшлыг ачсан хоёр тэрэг хөдөллөө. Дараачийн өдөр Гэндальфыг хүлээж өнгөрөв. Фродогийн тавин насны ойн өглөө дурсгалт найрын өглөө шиг цэлмэг сайхан байлаа. Харин Гэндальф байдаггүй. Үдэш болоход Фродо уйтгар гунигаа үргээхийн тулд баярын таван ширээ засав. Найз нараасаа ч гэсэн салах цаг болж байна.

Мерри Дэндүүдэлдэн, Фредегар Минж, Фолко Талх, Ногоон Молтогчин нарын хэдэн залуу хоббит дуу шуугиантай, санаа амар найрлаж, өчнөөн олон дуу хоолой мэдэн орилж, байсан байгаагүй баахан дурсамж ярьж, Фродогийн төрсөн өдөрт тогтсон заншил ёсоор эхлээд Бильбогийн эрүүл мэндийн төлөө, дараа нь хоёулангийнх нь эрүүл мэндийн төлөө ууцгаалаа. Дараа нь цэвэр агаараар амьсгалахаар гарцгааж, оддыг хараад унтахаар орцгоолоо. Гэндальф л ирсэнгүй.

Өглөө нь тэд тав арван гараараа сүүлчийн ачааг ачицгаав. Ачааг Мерри, Пин /Фредегар Минжийг тэгж нэрлэдэг байв/ хоёр хүргэлээ.

- Шинэ байшинд хоёр залхуугийн нэг нь пийшин галлана биз дээ, за за, та хоёр замдаа нам унтчихгүй бол нөгөөдөр уулзъя гэж Фродо хэлэв.

Фолко өглөөний цай уучихаад харихаар явж, Пин үлдэв. Фродогийн сэтгэл тавгүй байсан тул, Гэндалфыг бүрий болтол хүлээхээр шийдэв. Хэрэв шидтэнд үнэхээр чухал хэрэг байгаа бол Молтогчингийн судагт өөрөө хүрээд очно биз, аягүй бол хамгийн түрүүнд очно биз гэж бодоод Фродо Хоббитаныг сүүлчийн удаа сайн харж авахын тулд Туулайн гарамд тойруу замаар хүрэхээр шийдэв.

- Далимд нь өөхөө жаахан хайлуулаадахья – гэж тэр хоосон шахуу үүдний танхим дахь тоосонд дарагдаж, салж унах дөхсөн босоо толинд харангаа өөртөө хэлэв.

Үд болов уу, үгүй юу Любелия хялман шар хүү Лоттогоо дагуулан орж ирлээ.

– Арай гэж цаг боллоо – гэж тэр босго давав уу үгүй юу хэлсэн нь бүдүүлэг бөгөөд худал үг байв. Фродо шөнийн арван хоёр цаг хүртэл Уутан хясааны эзэн хэвээр байх ёстой билээ. Гэвч Любелитэй юугаа ярих вэ дээ, хөөрхий анх энэ эдлэнд эзэн суух гэснээсээ хойш дал гаруй жил хүлээж нас нь зуугийн босго давчихаад байгаа билээ.

Зүгээр ч нэг ирсэнгүй, Дэндүүдэлдэнгийнхэн болон бусад элдэв юмнууд хүний эд хогшил “андуураад” авчихаж магадгүй гэж шалгах, далимд нь түлхүүр авахаар иржээ. Түүнийг гаргах амаргүй: тэр зарагдсан эд хогшлын жагсаалт авчирсан бөгөөд бүх юм байрандаа байгаа эсэхийг шалгана гэв. Хоёр дахин нягталж шалгаад, нөөц түлхүүрүүдийг авч, гурав дахь түлхүүрүүдийг Скромбийнд орхино гэсэн ам баталгаа авлаа. Тэгэхдээ – тэр муу Скромбийнхныг мэдэхгүй биш, өглөө болоход эд хөрөнгийн тал нь алга болсон байх вий гэж хэл ам таталсны эцэст нэг юм гарлаа.

Фродо түүнээс цай уух уу ч гэж асуусангүй. Харин өөрөө гал зуухны өрөөнд Пин, Сэм хоёртой ханатлаа цайлав. Сэм түүнтэй хамт Забренди орж, “эзэн тэнд ямаршуухан төхнөж байгааг үзэх, ямар ямар ургамал тарих санаатай байгааг мэдэх”-ээр тохирсон байв. Жихар энэ санааг сайшаасан боловч зарим нь зугаалахаас өөр юм бодохгүй юм, зүгээр ч үгүй бас намайг Любелитэй хөрш болгочихож байгаа юм даа хэмээн үглэхээ мартсангүй.

- За Уутан хясаанд сүүлчийн цайгаа уучихлаа – гэж Фродо хэлээд сандлаа шийдэмгий түлхэв. Любелид төвөг удахын тулд сав суулгаа угаасангүй. Сэм, Пин хоёр гурван шуудайны амыг боогоод довжоон дээр гаргав. Пин цэцэрлэгээр зугаалахаар гарч, Сэм хаа нэг тийш алга болов.

Нар шингэж, Уутан хясааны эдлэн нэг л зэвүүн, хоосон харагдана. Фродо дасал болсон өрөө тасалгаануудаар ороход жаргаж буй нарны гэрэл бүүдгэрч, булангуудаас харанхуй сүүдэр босч ирлээ.

Төдөлгүй бүрэнхий болов. Гэнэт Гэндалф гараад ирж магадгүй гэж найдаад Фродо цэцэрлэгийн хаалган дээр очив.

Цэлмэг тэнгэрт одод яралзаж эхлэв.

- Сайхан шөнө болох нь дээ. Алхаж явахад сайхан. Оройтож гүйцлээ, хөдөлье, Гэндальф араас гүйцээд очно биз – гэж тэр хэлээд байшин руу эргэснээ зогсосхийж чимээ чагнав. Хажууханд нь, Исторбинкийн талаас л бололтой хоёр хүн ярилцах сонсдов. Нэг нь хөгшин Жихар, нөгөө огиудас хүрэм зэвүүн үл таних дуу хоолой байлаа. Танихгүй этгээд юу асуусныг ойлгосонгүй, хөгшин Скромби ихэд болгоомжилсон, бага зэрэг айсан дуугаар хариулж байна:

- Үгүй ээ, ноён Торбинс явчихсан. өнөө өглөөхөн манай хүү Сэмтэй хамт, хамаг юмаа аваад явчихсан, зараагүй эд хогшлоо зөөчихсөн... Яагаад гэдэг нь надад хамаагүй л дээ. Хаашаа байх вэ дээ, Молтогчингийн судаг руу, цаашихнаа ч байж магадгүй, хүн бүхэн мэднэ дээ. Энэ замаар шууд явна. Би очиж үзээгүй ээ, тэндхийнхэн өөдгүй. Үгүй үгүй, юу ч дамжуулахгүй. Сайхан нойрсоорой.

Хясаанаас зөөлөн алхан цаашилцгаалаа. Наашилцгаасан биш, цаашилцгаасанд нь яагаад ийм их баярлаж байгаадаа Фродо гайхав. “Элдэв асуулт, шалгаалтаас ядарсан бололтой. Мөн ч сониуч ардууд шүү” гэж тэр бодов.

Тэр Скромби өвгөнтэй уулзаж хэн гээч нь таныг хоргоов гэж асуух гэснээ гэнэт больж, Уутан хясаа руу хурдан хурдан алхав. Пин шуудайтай юмаа налан суугаад унтаж байна.

Сэм алга. Фродо харанхуй хаалга руу шагайж:

- Сэм, чи хаана байна, хөдөлье- гэж дуудав.

- Очлоо эзэнтэн минь – гэж Сэм хаа нэгтээ гүнээс хариулаад амаа арчсаар гарч ирэв. Тэр зооринд байгаа пивоны торхтой салах ёс гүйцэтгэжээ.

Фродо дугариг хаалгыг хааж түгжээд түлхүүрийг нь Сэмд өгч:

- Гэр рүүгээ гүй, тэндээс шууд нугын цаадах хаалга руу яв. Тэнд уулзъя, гудамжаар явахгүй, тандацгааж байгаа. За түргэл! – гэж тушаав. Сэм харанхуйд уусан далдрав.

- За гарцгаая даа – гэж Фродо Пинд хэлэв. Тэр хоёр шуудайтай юмаа үүрч таяг бариад хясааны баруун хана даган алхлаа.

Үүрд баяртай – гэж Фродо харанхуй цонхнууд руу харж аяархан хэлээд гараараа даллаад (яг л Бильбо шиг, гэхдээ өөрөө энэ тухай мэдсэнгүй) Пиний араас цэцэрлэг рүү эргэв. Тэр хоёр намхан хайс даваад харанхуйг сүвлэж, өндөр ургасан өвс шаржигнуулан тал руу орлоо.

Тэд баруун налуу руу бууж нарийхан гудам руу орох хаалганд хүрэв. Тэнд зогсоод шуудайныхаа оосрыг чангалж байтал Сэмийн хөлийн чимээ гарч амьсгаадах нь сонсогдлоо. Тэр чинээнд нь тултал чихсэн шуудайгаа мөрөн дээрээ тавьж, малгай бололтой үнгэлдсэн эсгий толгойдоо угласан байх бөгөөд харанхуйд харахад яах аргагүй гном харагдаж байв.

- Хүнд юмнуудаа надад өг, эмгэн хумс мэтийн хөөрхий амьтас оромж болоод хог новшоо нуруун дээрээ үүрч явдаг юм – гэж Фродо хэлэхэд:

- Миний үүргэвч хөнгөхөн эзэн минь, дээр нь хичнээнийг нэмсэн ч болно – гэж цайлган

мөртөө хуурамч дуугаар хэлэв.

- Үгүй шүү Сэм, яаж ийгээд даана, нэгэнт өөрөө ийм их ачаа авсан юм чинь тэнцүү хувааж үүрнэ шүү - гэж Пит хэлээд – мань эр нэлээн өөхөлчихөж, яваад ирэхээр өөрөө ч, ачаа нь ч хөнгөрнө гэв.

- Хүч чадалгүй хөгшин хоббитыг өрөвдөж үзээрэй, замын төгсгөлд салхины аясаар найгана вий- гэж Фродо инээгээд, - за дэмий ярих ч яамай, Сэм чи хэрээсээ хэтэрсэн их ачаатай байна, нэг амрахаараа хувааж үүрнэ – гээд үүргэвчээ авч:

- Шөнийн зугаалганаас сайхан юм хаа байна, гурав дөрвөн бээр алхаад хажуу тийш эргэнэ – гэлээ.

Тэр гурав гудмаар баруун зүг явж дараа нь зүүн тийш эргээд тал руу орж, ногооны талбайнуудын хажуугаар бутан хашаа даган шөнийн чимээгүй манан дунд галуун алхаагаар шогшив. Бүгдээрээ бараан цувтай учир гурвуулаа шидэт бөгж зүүсэн мэт харагдах бараагүй байлаа. Гурван хоббит чимээ гаргалгүй, таг дуугүй явж байхад араас нь мөрдөх амаргүй. Бүр талын соргог амьтад хүртэл чимээгүй аянчдыг харахтай үгүйтэй байлаа.

Норгордоос баруун тийш урссан горхинуудыг гаталлаа. Тахирласан хар тууз мэт горхины хоёр эргээр өтгөн бут ургаж, мөчрүүд нь усанд дүрэгджээ. өмнө зүг дахиад ганц бээр алхаад тэд Брендидуимын гүүрнээс эхэлсэн өргөн замыг гэтлэв. Укроль хүрээд зүүн өмнө тийш эргэж Ногоон Толгодыг зүглэн шогшлоо. Жим уул өөд өгсч, эргэж харвал Голын хөндийгөөр тархсан Норгордын гэрэл бүдэгхэн гялалзана. Төдхөн аялагчид хэдэн гүвээ даваад булингарт саарал устай цөөрмүүд бүхий Голын хөндийд орж ирэв. Моддын дундуур захын байшингийн цонхны гэрэлд сүүлчийн удаа харагдав. Фродо эргэж хараад гараараа дохилоо.

- Бид энэ хөндийгөө дахиж хараа ч уу, үгүй ч үү - гэж тэр аяархан хэллээ.

Гурван цаг яваад ямар ч байсан амрахаар шийдэв. Цэнгэг, сэрүүхэн, яралзсан одтой шөнө боловч утаалаг манан бэлийн нуга болон гүний горхинуудаас гарч ирээд толгод өөд мөлхөж гараад сууж байлаа.

Эргэн тойрны хус модод манай гурван хоббитын дээгүүр ганхаж, нарийхан мөчрүүд нь тэнгэрийг хааж байна. Тэр гурав даруухан оройн зоог бариад цааш хөдлөв. Удалгүй тэд манан дунд сүүмэлзэх толгодоор өгсч уруудсан нарийхан зам дээр гарч ирлээ. Энэ бол өтгөн ой, түүний салбарууд болон Зайгорд руу хөтөлсөн зам бөгөөд Голын хөндийгөөс алслан Ногоон толгод, Ойн булан, Дорно тойрогийн бөглүүд газарт хүрдэг ажээ.

Дараа нь тэр гурав өндөр ургасан моддын дундуур явсаар гүн жалга руу орж ирэв. Хөл дор хатсан навч шаржигнаж, юу ч харагдахааргүй тас харанхуй байв. Эхлээд мань гурав ярилцаж, аяархан дуулж явлаа. Хэн ч сонсохгүй юм чинь. Тэгээд дуугүй алхаж, Пин хоцорч эхлэв. Эгц давааны өмнө ирээд тэр зогсч эвшээлээ.

- Ёохх, унтмаар байна, шууд хэвтээд л унтлаа, та нар явуут унтах гэж байгаа юм уу? Шөнө дунд болж байна шүү дээ

- Би чамайг шөнө зугаалах дуртай гэж бодож байсан юм. За яахав, одоохондоо хаашаа ч яарах юм билээ. Мерри биднийг нөгөөдрөөс нааш ирэхгүй гэж бодож байгаа. Бидэнд нөөц нэг өдөр байна. Одоо аятайхан газар олоод хоноё - гэж Фродо хэлэв.

- Баруунаас салхилж байна, энэ толгойг тойрч үзье эзэнтэн минь, тэнд аятайхан газар олдох байх, гацуурын хуурай хэсэг байна – гэж Сэм хэлэв.

Норгордын орчимд хорь орчим бээр явж байсан, түүний хувьд түүнээс цааш газар үгүй байлаа. Ойт толгойн бараг орой дээр гацуурт төгөлд хүрч, хуурай мөчир, боргоцой түүж гал асаав. Зуун наст том гацуурын үндэсний дэргэд асаасан гал хөгжилтэйхэн бүжиглэж, мань гурав дулаацаж, толгой дохиж эхэллээ. Үндэснүүдийн дунд хүссэнээрээ тухалж, хөнжил, цуваа нөмрөөд хэвтсэн даруй нам унтацгаав.

Харуул гаргасангүй, Фродо хүртэл болгоомжилсонгүй, Хоббитанд байна шүү дээ. Гал унтарч, ганц хоёр жижиг араатан унтагчдыг харахаар иржээ. Хажуугаар санамсаргүй гүйж явсан үнэг нам зогсоод үнэртэж байна.

“Хоббитууд л байна. Эргэн тойронд сонин хачин явдал зөндөө, гэтэл гурвын гурван хоббит ой дотор модны ёроолд унтаж байдаг, энэ ч нэг л биш дээ” гэж тэр бодлоо.

Бүүдгэр чийглэг өглөө боллоо. Фродо түрүүлж сэрээд, гацуурын үндсэнд нухлагдсан нуруугаа тэмтэрч үзээд дуу алдав. Хүзүү нь эргэж харахааргүй болжээ. “Мөн зугаалав аа, тайван ч явж болохгүй. Гэтэл миний дуртай өдөн орон дээр Лякошелийнхэн унтаж байгаа, тэднийг энэ үндсэн дээр унтуулах юмсан” гэж бодов. Тэр сайн суниаж аваад:

- Хоббитууд аа, босоорой, ямар сайхан өглөө болж байгааг хараач- гэж хашгирав.

- Ямар өглөө болж байна? гэж Пин хөнжил дороосоо өрөөсөн нүдээрээ харангаа хэлээд:

- Сэм! өглөөний цай ес гучид бэлэн байлга, нүүр угаах ус халаасан уу?- гэлээ.

Сэм айсан мэт босон харайгаад эргэн тойрноо эргүү юм шиг хараад:

- Үгүй ээ, эзэн минь, халаагаагүй гэж шал нойрмог дуугаар хэлэв.

Фродо Пиний дээрээс хөнжлийг нь авч хаяад, нэг өшиглөчихөөд ойн цоорхой руу оров. Тэнгэрийн дорно хаяанд долгиолсон манан дээгүүр тэргэл улаан наран гарч ирлээ. Намрын алтан шаргал гоёлоо өмссөн модод манангийн тэнгист умбажээ. Зам зүүн доод гүн жалга ороод алга болжээ.

Фродог эргэж ирэхэд наад хоёр нь галаа асааж байв.

- Ус - гэж Пин хашгираад – Ус хаа байна? гэхэд Фродо:

- Би халаасандаа ус хийж явдаггүй

- Чамайг усанд явсан гэж бодсон юм – гээд Пин идэх юм гаргаж төмөр аягануудаа өрөх

зуураа:

- Одоо аваад ир!

- Хоёулаа явна аа, бас дашмагуудаа аваарай!

Доор уулын түргэн горхи шуугиж байв. Мань хоёр хоббиттой чацуу өндөр саарал чулуун дээрээс бууж байгаа уснаас дашмагууд болон аяны тогоогоо дүүргэж авлаа. Цэв хүйтэн усаар гар нүүрээ угаалаа.

Яаралгүйхэн цайлж аваад шуудайнуудаа нямбайлан боож, арван нэгэн цагт хөдлөв. Цэлмэг өдөр болж, нар улам хурц шарж эхлэв. Доош шулуухан бууж, горхи гатлаад налуугаас налууд, толгодоос толгодод өгсч уруудан алхахад цув, хөнжил, хоол хүнс, бусад зүйлсээ хийсэн шуудай үүргэвч алхам тутамд хүндэрч байх шиг санагдана. Удалгүй ядарч, хөлс урсч эхэлсэн ба зам улам л муруйж тахирлан толгод өөд өгсч, дахин уруудаж явсаар нэг мэдэхэд өргөн хөндий рүү шулуун уруудлаа. Тэдний өмнө удам сийрэг ой үргэлжилж, алсад өтгөн ойтой залгасан харагдана. Ойн булан, түүний цаана Брендидуим гол. Ямар их хол явах хэрэгтэй байдаг, зам улам л тахирлаж, эцэс төгсгөлгүй үргэлжилнэ.

- Зам улам цаашилж байна. Цаашилж л байг, харин би цааш явахгүй, тэгээд ч өдрийн хоолны цаг болж байна – гэж Пин хэлэв. Тэр замын хажууд суугаад дорно зүг ядрангуй харав. Тэнд, хязгааргүй үргэлжлэх бүгчим халуун талын цаана мэдээ орох цагаасаа л эрэгт нь амьдарч байсан танил гол харагдана. Сэм хажууд нь зогсов. Түүний дүгрэг нүд үл мэдэх алс хязгаар руу тэмүүлжээ.

- Эльфүүд энэ ойд амьдардаг уу?

- Ямар ч эльфүүдийн талаар би юу ч сонсоогүй юм байна – гэж Пин түс тас хэлэв. Тэр өөрөө ч дорно зүг рүү хөтөлсөн зам руу анх удаа харж байгаа юм шиг харж байлаа. Тэгснээ гэнэт хэнд ч хандалгүйгээр тод чангаар ингэж уншив.

Уйтгар гунигийг улан дороо гишгэн

Унаагүй аялагч минь аяндаа гаръя,

Уртын зам үүдэн дээрээс эхлэн

Мянган замыг хэлхэн

Нэгэн их мөрөн болгож

Намайг даллан алсад оджээ.

Хаашаа хөвөхөө л би

Харахан мэдэхгүй байна.

- Хөгшин аварга Бильбогийн шүлэгтэй төстэй байх чинь, эсвэл чи түүнийг дуурайж зохиогоо юу? Сэтгэл нэг л сэргээхгүй байна даа – гэж Пин хэлэв.

- Өөрөө зохиосон уу, өөр бусад зохиосон уу гэдгээ ч мэдэхгүй байна, зохиож байгаа юм шиг л хэлний үзүүрт гараад ирлээ, аль эртнээс мэддэг байсан ч байж мэднэ. Харин Бильботой, ялангуяа явахынх нь өмнөх сүүлийн жилүүдийн Бильботой бүр ч адилхан байна. Ертөнц дээр их мөрөн шиг ганцхан л зам байдаг. Тэр замын эх хаалга болгоны дэргэд байдаг, ямар ч жим түүний цутгал байдаг юм гэж тэр дахин давтан хэлдэг байсан. “Хаалгаар гарахад ямар хэцүү байдгийг мэдэх үү? Зам дээр хөлөө тавимагц хөлдөө шууд найд, тэгвэл хэрээ ясаа аваачиж тавиагүй газарт дорхноо л хүрчихнэ. Тэр жимийг харж байна уу? Тэр жим Балар шугуйг гатлаад Зожиг ууланд хүрнэ, тэндээс шууд л мянган уул, түмэн гол руу оруулна” гэдэг байсан. Уутан хясааны довжооноос хол зугаалах болгоныхоо дараа ингэж ярьдаг байсан юм.

- Тэгвэл би ингэж хэлье. Цагийн дараа энэ зам намайг хааш нь ч хүргэхгүй – гэж Пин үүргэвчнийхээ оосрыг мултлах зуураа хэлэв. Дараа нь Сэм, Фродо хоёр үүргэвчээ тавьж, замын далан дээр хөлөө зам руу харуулан үүргэвчээ дэрлэн хэвтээд өгөв. Амарч сайн хооллож аваад дахин тухтай амарлаа.

Нар тэнгэрийн өрнө хаяа руу тонгойж, хоббитуудыг толгодоос бууж явах үес үдшийн өмнөх гэрлээ цацрааж байлаа. Одоохондоо тэд нэг ч амьд амьтан харсангүй, Ойн булан руу явах амьтан цөөн, ер яах ч гэж явах юм билээ? Гурван аянч өтгөн өвс ургасан замаар хоёр цаг орчим явсны дараа Сэм гэнэт зогсон чимээ чагнав. Дандаа тахирлаж байсан зам одоо шулуухан болж, өндөр ургасан өвс ургамлын дундуур алсалж хааяа хааяа цөөн мод харагдах болсон нь ойд ойртож байгааг аянчдад хэлж байв.

– Биднийг морь гүйцэж ирж байх шиг байна. Дөнгөж сая зам эргэсэн, эргэлтийн цаана үзэгдэхгүй байна – гэж Сэм хэлэв.

- Гэндальф юм болов уу?- гэж Фродо хэлсэн боловч тэр дороо Гэндальф биш байна гэж мэдрээд хэн ч байсан хамаагүй энэ морьтноос хурдхан нуугдах хүсэл төрөв.

- Айх юм алга, гэлээ ч гэсэн биднийг зам дээр харах хэрэггүй. Хэрэв энэ Гэндальф бол хойшид хожимдохгүй байхын тулд сайхан угтана. За алив нэг- хоёр- гурав – тарж гүйгээд нуугдаж хар – гэв.

Сэм, Пин хоёр зүүн тийшээ гүйж, далангаас холгүй хонхорт далд оров. Фродо хоцорлоо. Сониуч зан юм уу юу юм бэ, нуугдахад саад болоод байлаа. Туурайн чимээ дөхөж ирлээ. Фродо дөнгөж замын хажуу дахь модны цаадах өтгөн өвс рүү шургаж ороод бүдүүн үндсэн дээр толгойгоо тавьж амжлаа.

Замын эргэлтийн цаанаас хоббитын понид хавьтахгүй том хар морь, түүний дээр эмээл дэрээ бөгтийсөн өндөр морьтон гарч ирэв. Нэлмэгэр хар цуван дороос зөвхөн дөрөө, урт давируултай гутал харагдана. Нүүрээ юүдэнгээр халхалжээ.

Морь Фродогийн нуугдсан модны дэргэд зэрэгцэж ирснээ нам зогсов. Морьтон ч хөдөлгөөнгүй, чагнаж байгаа бололтой. Сөөнгө шуухитнаан Фродод сонсогдож, морьтны

толгой баруун тийш эргэснээ зүүн тийш эргэв. Тэр ямар нэг үнэр авсан юм шиг байв. Фродо гэнэт ухаангүй айдаст авгаж, одоо намайг олно... гэж бодонгуут бөгжөө санав. Тэр амьсгалах зориг ч хүрэхгүй, өчүүхэн хөдлөхөөс ч айж байсан боловч бөгж түүний цорын ганц аврал болж, гар нь өөрийн эрхгүй халаас руугаа явлаа. Түргэн л зүүе, зүүчих юм бол айх юмгүй болно. Гэндалф битгий зүү гэсэн... за яадаг юм бэ, Бильбо зүүж л байсан, яагаа ч үгүй, би өөрийнхөө орон нутаг Хоббитандаа байна гэж бодоод бөгжинд хуруугаа хүрэх хоромд морьтон нуруугаа цэхэлж жолоогоо дугтрахад морь итгэлгүйхэн хөдөлж, жигдхэн сайварлан одов.

Морьтон бүрий барай алсад уусан одсоны дараа Фродо босч далан дээр мөлхөж гараад араас нь харлаа. Тэртээ алсад хар морь баруун тийш эргэж, замын хажуугийн төгөл рүү орлоо.

– Айхгүй ч гэсэн аягүй л юм байна – гэж Фродо нөгөө хоёр дээрээ очих зуураа бувтнав. Пин, Сэм хоёр өвсөн дотор түрүүлгээ харан нүүрээ газарт нааж хэвтсэн учир юу ч харсангүй, Фродо тэр хоёрт үл ойлгогдох морьтны тухай ярьж өгөв.

- Яагаад гэдгийг би мэдэхгүй, гэсэн ч тэр намайг эрж шиншилж байна гэдэгт итгэлтэй байна. Би тэрэнтэй тааралдахгүй юмсан гэж маш их хүсч байна. Хачин юм даа, Хоббитанд ийм гийчин хэзээ ч ирж байгаагүй.

- Том ардад бид ямар хамаатай юм бэ? Тэр яах гэж энд ирэв? Тэрэнд юу хэрэгтэй юм бэ? – гэж Пин үглэнэ.

- Хүмүүс ч ирдэг л юм. өмнөд тойрогт байх аа, ухаан муутай Аваргуудтай хэрүүл зодоон хийж байсан. Харин ийм морьтнуудын тухай сонсоо ч үгүй юм байна. Хаанаас гараад ирдэг юм бол?

- Өршөөгөөрэй, би хаанаас ирснийг нь мэдэж байна. Энэ хар морьт Норгордоос ирсэн, тэр энд гав ганцаараа яваа. Хаашаа явж байгааг нь ч мэдэж байна.- гэж Сэм ярианд оролцов.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? – гэж Фродо Сэм рүү гайхан харангаа ширүүн асуув. – Мэдэж байдаг, тэгээд хэлдэггүй юм уу?

- Би дөнгөж сая л саналаа, өршөөгөөрэй эзэнтэн. Ийм юм болсон: Би өчигдөр аавдаа түлхүүр өгөх гээд очиход өвгөн маань “Тэнэг өвгөн би чамайг ноён Фродотой өнөө өглөө явчихсан гэж бодож байсан юм. Энд нэг амьтан Уутан хясааны Торбинс хаашаа явсан бэ гэж шалгаагаад. Тэр хаачдаг юм бэ, яваад л өгсөн, тэгээд л тэр. Би тэрнийг Молтогчингийн судаг руу явуулсан. Тэр надад тун ч таалагдаагүй, ойлгож байна уу. Ноён Торбинс яваад өгсөн, эргэж ирэхгүй гэж би хэлсэн. Тэгсэн чинь тэр над руу могой шиг исгэрсэн шүү. Тэр хаанаас ирсэн юм бэ гэж ааваас асуусан. “Хэн мэддэг юм бэ, ямар ч байсан хоббит биш, өндөр хар юм байсан. Тэр миний дээрээс бөхийгөөд шуухитнаад байсан. Их холоос, Том ардаас л ирсэн байх, яриа нь шулга юм билээ” гэж аав хэлсэн. Аавыг ахиж шалгаах цаг байгаагүй, та намайг хүлээж байсан, дараа нь хэлэхээ мартчихаж. өвгөн маань хараа муутай, тэр этгээд харанхуй болж байхад ирсэн. Аав бүгдийг зөв хэлсэн байх, би мартсан нь тун буруу юу, эзэнтээн?

- Өвгөнд ямар буруу байх вэ, тэр миний тухай асуусан харийн этгээдтэй ярьж байхыг би

өөрөө сонссон. Яах гэж байгааг нь мэдэх гэж ч оролдсон. Би очоогүй нь харамсалтай, чи надад хэлээгүй нь тоогүй. Бид болгоомжлох хэрэгтэй.

- Магадгүй энэ морьтон тэр биш байх, бид нууцаар гарсан, чимээгүй явсан, тэр биднийг мөрдөж чадахгүй – гэж Пин хэлэв.

- Яг тэрэн шиг шуухитнаад, үнэрлээд байсан, тэгээд ч пад хар – гэж Сэм хэлэв.

- Гэндальфыг хүлээхгүй гардаг буруудлаа, магадгүй зөвдсөн ч юм уу, хэлэхэд хэцүү юм даа

- Чи энэ морьтны тухай ямар нэг юм мэдэж байгаа юм уу, зүгээр л таамаглаж байгаа юм уу?

- Юу ч мэдэхгүй ээ, таамаглахаас айж байна.

- Чиний хэрэг ээ, эрхэм садан минь, нууцаа өөртөө хадгал, харин цаашаа яах вэ? би амарч, оройн хоолоо идмээр л байна, гэтэл хөлийн хурдаар урагшилсан нь дээр юм шиг байна. Үнэрлэдэг морьтнуудын тухай та нарын яриа бүр санаа зовоочихлоо.

- Тийм ээ, бид энд саатсаны хэрэггүй, тэгэхдээ замаар явахгүй, нөгөө хар морьт эргээд ирдэг ч юм уу өөр нэг нь гараад ирэх ч юм уу. Хурдхан алхъя, Туулайн толгод хүртэл их алхана шүү.

Замдаа дахин орсон аянчдыг үдэж моддын урт сүүдэр өвсөн дээгүүр сунайна. Одоо мань гурав замаас арав орчим сажин холдоод туйлын нууцгай алхаж байна. Хонхор хотгор, овгор товгор, байн байн модод өтгөрч хоорондоо хэлхэлдэх тул явахад тун ч амаргүй байв. Ой руу тэмүүлсэн олон бээрийн урт, шулуун замыг туулахаас өмнө тэдний ард наран шингэж байлаа. Зам гэнэт зүүн тийш огцом эргэж Йелийн хотгороор алсын салбар ой өөд хөтөлж, баруун талаар Ойн харш руу хөтөлсөн муруй зөрөг орсон үзүүр хязгааргүй хүчирхэг ой хөхрөн байна.

- Тийшээ явна гэж Фродо хэлэв.

Замын уулзвараас холгүй тэд аварга том өмхтэй мөртөө амьд, аль эрт хугарсан мөчрүүдийн шархыг тойрсон нарийн мөчрүүд ургасан модонд хүрэв. Модны уудам нүх рүү шургаж орох боломжтой бөгөөд замын талаас харагдахааргүй ажээ. Тэр гурав шургаж ороод унасан навч, өмхөрсөн холтос дээр суун аяархан ярилцах зуураа амарч хооллож авлаа.

Тэднийг дахиад замд гарахад бүрэнхий болсон байлаа. Баруун зүгийн салхи мөчир найгуулан санаа алдах мэт сэвшинэ. Навчис хоорондоо намуухан шивнэлдэнэ. Тэдний замыг зөөлөн бөгөөд аажмаар харанхуй залгиж байлаа. Дүнсийж харагдах дорно зүгт моддын дээгүүр одод гялалзав. Аянчид санаагаар унахгүйн тулд зэрэгцээд хөл нийлүүлэн алхаж байв. Цэлмэг тэнгэрт одод түгэхэд санаа зовохоо больж, туурайн чимээ чагнахаа болив. Тэр ч байтугай хоббит зангаар хамраараа дуу аялж эхлэв. Хоббитууд шөнөөр гэртээ харихдаа ингэж хамраараа аялдаг заншилтай. Голдуу оройн хоолны юм уу орондоо орох урилга дуу аялдаг боловч аялагч гурав аяны дуу (мэдээж бусад зүйлээс гадна оройн хоол, унтлагын урилга) аялж явлаа. Үгийг нь Бильбо Торбинс бичсэн, ая нь эндхийн уулсаас ч эртнийх бөгөөд Фродо Голын хөндийгөөр Бильботой зугаалж, адал явдал ярилцаж явахдаа сурчээ. Үг нь:

Нойрмог байшин хараахан унтаагүй

Нөөлөг гал задгай зууханд унтраагүй

Харин бид харихыг яарахгүй

Хаана ч, хэзээ ч үзээгүй

Хайрхан, суурин, хотыг

Харихаасаа өмнө үзэж магадгүй

Өвс ургамал бүгдээрээ

Өглөө болтол зүүрмэглэг

Үүрээр бид замдаа гарна

Үдэш болоход амрахыг урьдаг ч

Үнэндээ тэгдэг цаг биш.

Талбай, толгод, эдлэн, цэцэрлэг

Та бүгд чимээгүйхэн ард үлдэнэ

Аянчин бид багахан амраад

Аяны замдаа дахиад гарна

Хонгил зам, шидэт нислэг

Хойшдын замд хүлээгээ ч билүү

өнөөдөр бид хажуугаар нь

өнгөрөвч маргааш олно

Нар сарны араас элдэж

Нармай дэлхийг тойрон ниснэ.

Байшин маань нойрссон ч

Алсын харгуй даллан урьж байна

Саран гэрэлтэж байгаа цагт

Шөнийн харанхуй аймшигтай биш

Орчлон унтаж, зам мухардахад

Орон гэртээ эргэж ирнэ.

Будан манан, харанхуй шөнө

Буцаж одно, буцаж одно...

Гэрэлтэй ширээнд оройн хоол

Гэртээ бид тавтай амарна.

Ингээд дуу төгслөө.

- Модныхоо хонгилд тавтай амарна – гэж Пин дууны үгийг мушгив.

- Чимээгүй, дахиад туурайн чимээ гарч байх шиг – гэхэд гурвуулаа сүүдэр мэт нам жим болов. Хөндийг туурайн чимээ цочоож, одоохондоо хол дуулдавч салхин талаас улам ойртсоор байв. Тэд дүнсгэр моддын өтгөн сүүдэр рүү улам лав шургаж орлоо. – Зугтахгүй, бид харагдахгүй байгаа, дахиад бас нэг морьтон гараад ирэх нь үү, би хармаар байна – гэж Фродо шивнэлээ. Туурайн чимээ ойртсоор. Сайтар нуугдах цаг нэгэнт үгүй учир Сэм, Пин хоёр асар том хожуулын цаана нуугдаж, Фродо зөрөг замын хажууд хэвтэв. Зөрөг гэрэлтэй саарал судлаар ойн харанхуйг сүвлэж байв. Дээр одод гялалзавч саргүй.

Туурайн чимээ гэнэт намдаж, моддын дундуур хар дүрс сүүмэлзэж хэн нэгэн морь хөтөлж яваа мэт хоёр сүүдэр хоорондоо харанхуйд уусч байхыг Фродо харав. Дараа нь тэр гурвын замаас гарсан хэсэгт хар дүрс гараад ирэв. Сүүдэр хөдөлж, анхааралтай аяархан шуухитнах чимээ сонсдоод сүүдэр доош сууж Фродо руу мөлхөх шиг. Фродо дахиад л бөгжөө зүүх тухай бодов. Тэгээд хэн нэгний тушаалд захирагдах мэт юу хийж байгаагаа мэдэлгүй халаасан дотроос бөгжөө олов. Аймшигтай нам жимийг эвдэж гэнэт чангаар дуулах, хөнгөн инээх сонсдов. Хөгжилтэй хонх жингэнэх мэт цэвэр хоолой шөнийн сэрүүхэн агаарыг доргиоход хар сүүдэр босч, арагш ухран морины сүүдэртэй нийлээд замын цаадах харанхуйд уусан алга болов. Фродо нэг сайхан амьсгал авлаа. – Эльфүүд! Эльфүүд ноёнтоон – гэж Сэм нойрмог сөөнгө хоолойгоор дуу алдаад дуулсан зүг рүү ухасхийсэн боловч наад хоёр нь барьж авлаа. – Тийм ээ эльфүүд байна, энэ чинь Ойн булан шүү дээ. Тэд үүгээр бараг жил бүр хавар, намраар явж өнгөрдөг юм. Яг цагаа олж ирлээ. Хар морьт яарч ирээд шууд бидэн рүү мөлхөж байсан, хэрэв дуу байгаагүй бол мөлхөөд ирэх байлаа... Дуунаас айгаад зугтаачихсан. – Эльфүүд дээр очих юм уу, үгүй юм уу – гэж Сэм яаруулав. Хар морьтыг тэр аль хэдийн мартжээ.

- Сонсохгүй байна уу, тэд өөрсдөө ирж байна, зөвхөн хүлээх л хэрэгтэй.

Дуу наашилсаар. Нэгэн тод цээл хоолой бусдаас чанга дуулна. Дууны үг нь маш эртнийх, ганц Фродо л арайхийн ойлгож байв. Гэвч дахилт нь үгээ тодотгож байлаа. Фродо ингэж ойлгов:

Алсын далайн цаадах

Шөнийн гэрлийн туяа

Манай уулсын дээгүүр

Мөнхийн найдвараар гэрэлт!

О Элберет! Гилтониэль!

Алсын найдварын гэрэл минь ээ

Бүрэнхий энэ л газраасаа

Гүнээ мэхийн ёсолъё!

Тэнгэрийн хар хаяанд та

Түнэр харанхуйг ялсан билээ

Шөнийн титэм дээрээ та

Гэрэлт оддыг асаасан билээ

Гилтониэль! О Элберет!

Цэнхэр сүмийн туяа минь!

Алсын далайн чанад дахь

Ашдын гэрлийг тань санаж байна бид.

Дуу ингээд төгсөв.

- Эд нар чинь далайн чанадын эльфүүд байна шүү дээ. Элберетийн тухай дуу байна. Эд нар манай Хоббитанд тун ховор үзэгддэг, Дундад газарт бараг байхгүй. Хачин юм даа. Хоббитууд замаас холгүй суугаад хүлээж байв. Төдөлгүй эльфүүд хүрч ирлээ. Оддын гэрэлд тэдний нүд гялалзан үс нь намирч, хөл дор нь мөнгөлөг жим үүсч байлаа. Тэд чимээгүй өнгөрч байтал сүүлд нь явж байсан эльф хоббитууд руу эргэж харснаа инээж:

- Энэ чинь Фродо гэж үү? Оройхон байна даа, Төөрчихөө юу? – гэснээ бусдыгаа дуудахад тэд мань гурвыг хүрээлэв.

- Гайхамшиг гэхээс өөр юу гэж хэлэх вэ, гурван хоббит шөнө дунд ойд. Бильбогийн үеэс хойш ийм юм байгаагүй. Юу болсон юм бэ?

- Юу ч болоогүй ээ, гайхамшигт омгийнхон минь, зүгээр л бид зам нийллээ. Би оддын дор зугаалах дуртай, хамт явбал баярлах байна.

- Та наргүйгээр явж дөнгөнө, салж өгдөггүй хоббитууд минь – гэж тэд инээлдээд- та нар зам нийлнэ гэж яаж мэдэж байгаа юм бэ, бид хаа хүрэхийг та хэд мэдэхгүй шүү дээ!

- Намайг та нар яаж мэдэж байгаа юм бэ? – Фродо асуув.

- Мэдэж ядаад байх юм байхгүй, чамайг Бильботой хамт явж байхыг олон удаа харсан. Харин чи л биднийг хараагүй байх.

- Та нар хаашаа явж байгаа юм бэ? Удирдагч чинь хэн нь юм бэ?

- Би, Харальд- гэж хоббитуудыг анх харсан эльф хэлээд –Славурын өвдөгний Харальд байна. Бид хөөгдсөн, манай овгийнхон аль хэдийн явчихсан, бид далай орно. Уудам хөндийд манайхнаас үлдсэн л дээ. Ер нь өөрийнхөө тухай ярьсан нь дээр Фродо. Чиний ямар нэг юм болохоо байж дээ, янз нь.

- Бүхнийг мэдэгч ард минь – гэж Пин ярианд оролцоод – Хар морьтнууд гэж хэн юм бэ, хэлээд өгөөч!

– Хар морьтнууд гэнэ ээ? – гэж тэд хоорондоо аяархан ярилцаад – Тэд та нарт ямар хэрэгтэй юм бэ?

– Бидний араас хоёр нь мөшгөөд байсан.. нэг ч байж магадгүй, та нарыг ирэнгүүт холдлоо. Эльфүүд шууд хариулсангүй, өөрийнхөө хэлээр зөвлөлдөөд дараа нь Харальд: - Бид энэ тухай ярихаа азная. Харин та нар бидэнтэй яв. Манайд ийм заншил байхгүй, гэхдээ хамт яв, бидэнтэй хамт хоно.

– Үнэхээр гайхалтай ард юм аа, би найдаагүй шүү- гэж Пин хэлэв. Харин Сэм баярласандаа дуугарч чадахгүй шахам байв.

- Баярлалаа чамд, Славурын өвдөгний Харальд минь – гэж Фродо хэлээд мэхийн ёсолж - Элен сейла люменн оменнтиэяво – одод бидний уулзалтыг гийгүүллээ гэж эртний эльф хэлээр нэмэв.

- Өө найз нар минь гэж Харальд өөрийнхөндөө инээн хэлээд – яриагаа нууцлах хэрэггүй юм байна, бидэнтэй хамт эртний хэл мэддэг хүн явж байна. Бильбо гайхамшигтай сайн багш байна шүү! Эльфүүдийн найз чамд баяр хүргэе- гэж Фродод мэхийн хэлээд – бид зам нийлсэнд баяртай байна. Хөдөлцгөөе, гэхдээ хоцрохгүй, төөрөхгүйн тулд бидний дунд яв, зам урт шүү гэлээ.

- Урт гэнэ ээ, та нар хаашаа явж байгаа юм бэ?

- Ойн харшийн яг гүн рүү. Газар хол, гэвч тэнд амраад, маргаашийн зам тань богино болно.

Тэд чив чимээгүй, сүүдэр мэт сүүмэлзэх төдий явлаа, эльфүүд хоббитуудаас ч чимээгүй явдаг ажээ. Пин үүрэглэж, бүдэрч эхэлсэн боловч хажууд нь явсан эльф сугадаж авсан учир унасангүй. Сэм Фродогийн дэргэд унтаагаар явж байгаа юм шиг хачин баяр хөөртэй алхана.

Хоёр талын ой улам улам өтгөрч, мөчрөөрөө хоорондоо нийлсэн модод арай залуу, их бие нь зузаан байх бөгөөд удалгүй жим баруун зүүн талаасаа жимст бутны төглөөр хашигдсан налуу хөндий рүү орж ирэв. Эцэст нь эльфүүд төглийн гүн рүү эргэхэд илбийн юм шиг нарийхан ногоон зурвас нээгдэж: өндөр өндөр модод талаас хавчин байснаа гэнэт өмнө нь шөнийн гэрэлд өтгөн саарал харагдах тэгшхэн нуга гараад ирлээ.

Гурван талаасаа ойгоор хүрээлэгдсэн, зүүн талаасаа эгц налуу доош бууж, тэртээ дороос аварга моддын орой цухуйна. Эльфүүд ногоон дээр суугаад хоорондоо аяархан ярилцан хоббитуудыг хараа ч үгүй юм шиг байв. Хоббитууд цув, хөнжилдөө шургаад зүүрмэглэж эхлэв. Алсын хөндий дэх тосгоны гэрлүүд унтарч шөнө боллоо. Пин үндсэн дээр хацраа тавиад нам унтжээ. Дорно зүгийн тэнгэрт Оддын хэлхээ, Реммират гялалзаж, дөл цацруулсан бадмаараг мэт Боргиль манан нэвлэн гэрэлтэнэ.

Дараа нь гэнэт илбэдсэн юм шигээр тэнгэр цэлмэж, ертөнцийн захаас Тэнгэрийн илд баригч Мэнальвагор гялалзсан бүстэйгээ гялсхийн гарч ирэхэд эльфүүд чангаар дуулан угтав. Ойрхон газарт түүдэг галын хурц дөл бадрав. – Та нар чинь яачихав аа – явцгаая, ярьж хөөрч хөгжилдөх цаг боллоо – гэж хоббитуудыг дуудав. Пин өндийж суугаад нүдээ арчив.

- Тавтай морилно уу найзууд минь, гал асч байна, хоол болж байна – гэж нэг эльф нойрмог Пин рүү тонгойж хэлэв.

Ногоон нуга ойн гүн рүү орж ойн харш болж байгаа бөгөөд дээвэр нь моддын мөчир ажээ. Аварга модод харшийн багана үүсгэн эгнэж, төвд нь түүдэг гал дүрэлзэн мөчрүүдээс алтан мөнгөн дэнлүү гялалзана. Эльфүүд гал тойрон өвсөн дээр юм уу дугариг хожуул дээр суужээ. Зарим нь том хундага тараан дарс аягалж, зарим нь хоол тараана.

- Даруухан дайлж байгаад минь уучлаарай, бид гэртээ биш аяны замд байна. Харин та нарыг гэртээ очихоор жинхэнэ ёсоор хүлээж авна.

- Яалаа гэж, би төрсөн өдрөөрөө ч ийм сайхан дайлуулаагүй – гэж Фродо хэлэв.

Пин юу идэж, юу ууснаа дараа нь санасангүй. Тэр эльфүүдийн сайхан царайг харж тэдний дуу хоолойг сонсч байсан бөгөөд тэдний яриа өөр өөр боловч өөр өөрийнхөөрөө гайхмаар байсан бөгөөд гайхалтай сайхан зүүдэлж байгаа мэт санагдаж байлаа. Зөвхөн талх өгсөн, цав цагаан, гайхалтай сайхан амттай, бас том хундага уулын булаг шиг цэвэр, зуны үдэш мэт алтлаг өнгөтэй юм ууснаа санаж байв.

Сэм тэнд юу болсныг дараа нь үгээр илэрхийлэн ярьж чадаагүй боловч тэр сайхан баярт үйл явдлыг эцсийн өдрөө хүртэл санаж явсан билээ. Тэр нэг Эльфид:

- Эрхэм минь, миний цэцэрлэгт ийм алим байсан бол би жинхэнэ цэцэрлэгч байх байлаа. Гэхдээ юун алим, дуулбал ингэж л дуулах хэрэгтэй юм байна гэж хэлсэн юм. Фродо уугаад л, идээд л, яриад л байсан, ярихдаа үг сонгох гэж багагүй зүдэрч байсан. Тэр эльфээр арай чарай ойлгож байсан тул байдгаараа хичээн сонсч байв. Тэр өөрийг нь дайлсан хүмүүст ядаж төрөлх хэлээр нь талархлаа илэрхийлж байгаадаа баяртай байлаа. Тэд инээгээд л “Ай даа, хоббит” хэмээн баярлаж байлаа.

Дараа нь Пин унтаад өгөхөд түүнийг модны мөчрүүдийн хоорондох зөөлөн өвсөн дээр эвтэйхэн хэвтүүлсэн. Сэм толгой сэгсрээд, эзнийхээ дэргэдээс холдохгүй гэсэн. Пин долоо дахь зүүдээ зүүдэлж байхад Сэм Фродогийн хөлийн дэргэд суугаад л байсан, хичнээн тэссэн боловч эцэст нь тонгос гээд л унаад өгсөн. Фродоо унтахгүй их удсан, Харальдтай ярих зүйл их байсан юм. Тэр хоёр өнгөрсөн болоод өнөөгийн сэдвээр ярьсан бөгөөд Хоббитанаас гадуур болж байгаа сүүлийн үеийн үйл явдлуудыг Фродо их сонирхож байлаа. Эцэст нь тэр хэлнийхээ үзүүрт эргэлдээд байсан асуултыг тавилаа:

- Харальд! Тэр цагаас хойш чи Бильбог харсан уу?

- Харсан, хоёр ч удаа. Яг энд бид салсан, дараа нь эндээс их хол газар.

Хаана гэдгээ тэр хэлсэнгүй, Фродо асуусангүй.

- Чиний тухай ярья Фродо, чиний тухай зарим зүйлийг би мэднэ, би харцнаас чинь гадарласан. Чиний асуулт ч дэмий биш байлаа. Чи Хоббитаныг хүнд эргэлзээтэй орхиж байна. Би өөрийнхөө үйл хэргийн төлөө явж байна уу, энэ үйл хэргийг би бүтээж чадах уу гэж. Тийм үү?

- Тийм ээ, гэхдээ миний энэ үйл хэргийг ганцхан Гэндальф, бас энэ Сэм мэдэж байгаа гэж би бодсон юм – гээд Сэм рүү хартал тэр тухтай нь аргагүй хурхирч байв.

- Эльфүүдээс Дайсан руу нууц нэвтэрдэггүй

- Дайсан руу? Тэгэхээр чи ямар учраас би Хоббитаныг үүрд орхиж байгааг мэдэж байгаа байх нь ээ?

- Дайсан чиний мөрийг мөшгиж байгааг би мэдэж байна. Яагаад гэдгийг нь мэдэхгүй. Ямар ч гэсэн аюул чиний өмнө ч байгаа, ард чинь ч байгаа, тал талаас чинь заналхийлж байгаа гэдгийг тогтоож ав, Фродо!

- Чи морьтнуудын тухай ярьж байна уу? Тэднийг би Дайснаас явж байгаа гэж бодож байна. Тэд хэн юм бэ?

- Чамд Гэндальф юу ч яриагүй юм уу?

- Тэдний талаар юу ч яриагүй

- Тэгвэл мэдэх хэрэггүй, айдас хүчгүй болгодог. Миний бодлоор бол, чи сүүлчийн цагтаа амжиж байх шиг, хоцроогүй гэж найдаж байна. Битгий уд, битгий эргэж хар, Хоббитанаас аль болохоор хурдан гар!

- Чиний хагас дутуу үг шулуун ярианаас илүү айлгаж байна. Урд минь аюул байгаа гэдгийг би мэдэж байсан, гэвч ядаж өөрийнхөө Хоббитаныг аюулгүй өнгөрнө гэж бодсон юмсан.

- Хоббитан танайх биш, та нараас өмнө ч энд амьдарч байсан, хоббитууд үлгэр болсон хойно ч амьдрах болно. Та нар өөрөө өөртөө амьдардаггүй, хэрэв та нар ертөнцөөс тасарчихвал

ертөнц та нараас тасарч байгаагүй юу?

- Тийм юм шиг байна, гэвч манайд ямагт амгалан тайван, эвтэй найртай, тав тухтай байсан. Харин одоо яах болж байна? Би Забренди хүртэл чимээгүйхэн яваад тэндээс Уудам хөндий рүү явахаар шийдсэн юм. Гэтэл араас мөрдөөд ирж. Одоо яах вэ?

- Зорьсон газар руугаа яв. Миний бодлоор, эр зориг чамд хангалттай байна. Мэргэн зөвлөгөө бол Гэндалфын ажил. Чи ямар учраас аян замд гарсан, яагаад Дайсанд хэрэгтэй болсныг би мэдэхгүй шүү дээ. Гэндалф лав мэдэж байгаа, ганц энийг ч биш. Чи түүнтэй уулзана биз дээ?

- Найдаж л байна... Би сүүлчийн минут хүртэл түүнийг хүлээсэн, тэр хамгийн удлаа гэхэд хоёр хоногийн өмнө ирэх ёстой байсан юм. Юу болсон байж таарах вэ, чи юу гэж бодож байна? Түүнийг хүлээдэг юм билүү?

Харальдын царай барайж бодол болов.

- Муу мэдээ байна, Гэндалф хэзээ ч хожимддоггүй. Гэхдээ мэргэдийн хэрэгт хошуу бүү дүр, толгойгоо алдана гэсэн үг байдаг даа. Нэгэнт та хоёр тэгж тохирсон юм бол хүлээх байхаа өөрөө шийд.

- Өөр нэг үг ч байдаг: Эльф, салхи хоёроос үг бүү асуу, аль аль нь тийм бол үгүй гэж хариулна.

- Танайхан тэгж ярьдаг юм уу – гээд Харальд инээж – Дэмиэ яриа байна, ямар ч зөвлөгөө ухаанд сайн, ямар ч зам зовлон үүдэж болно. Тиймээс бид салхинд үг хаядаггүй. Чиний хувьд би хариулт сонгоход хүнд байна, чи өөрийнхөө үйл хэргийн тухай үг ч цухуйлгасангүй. Гэлээ ч гэсэн нөхөрлөлийн төлөө эрсдэл хийе. Гэндалф ирэхгүй бол хурдан яв, хамт аялах хүнээ заавал ол, ганцаар бүү яв. Найз нараа ажиглаад хамгийн найдвартайг нь ав. Зөвлөгөө өгсний төлөө надад талархлаа илэрхийл, би их дургүй өгч байна шүү. Эльфүүдэд өөрийн асуудал, өөрийн зовлон бий, бусдынхаас огт өөр. Бидний зам ховор нийлдэг, энэ удаа нийллээ, талаар өнгөрөхгүй байх, сүүлчийн удаа ч биш байх. Энэ талаар амаа хамхицгаая, илүүг хэлэхээс айж байна.

- Би чамд маш их талархаж байна. Гэвч хар морьтнуудын тухай яриагүй нь харамсалтай. Чиний хэлснээр бол Гэндалфгүй их удах нь шиг байна, гэтэл тэд хэн юм бэ гэдгийг би мэдэхгүй байдаг.

- Мэдэж ядах юу байна? тэд бол Дайсны гар хөл гээд л бодчих. Тэднээс зугт, нэг ч үг бүү соль, тэд бол үхэл. Намайг бүү шалгаа, яваандаа та нар тэдний талаар надаас ихийг мэдэх болно. Элберет чамайг ивээх болтугай, Дрогогийн хүү Фродо! Эр зоригийг хаанаас авах вэ? Надад их аймшигтай байна, эр зориг хүрэхгүй байна! Эр зориг хаанаас гардаг нь ойлгомжгүй, чамд хангалттай эр зориг байгаа гэж найд! Харин одоо унт! өглөө бид алга байна, элч бид илгээхгүй. Хэрэгтэй нэг нь чиний тухай мэднэ биз, хамгаалалтгүй, туслагчгүй бүү яв! Би чамд Эльфүүдийн найз гэж нэр өглөө. Энэ нэрийг дагуулж яв! Бид харийнханд ийм нэр өгөх нь ховор, харийнхнаас өөрийнхөө хэлийг сонсох нь ховор.

Фродо гэнэт унтаж байгаага мэдрэв. “Би нээрээ унтъя” гэж бувтнахад эльф түүнийг Пиний хажууд өвсөн дээр тавихад хөлөө жийгээд нам унтав.

Бүлэг 4

Мөөгөн дундуур

Фродо жигтэйхэн сэргэлэн цовоо сэрэв. Тэр бараг газар шүргэсэн том том мөчрүүдийн дор, анхилам үнэрт зөөлөн өвс, хөвдөн дэвсгэр дээр унтжээ. Наран ногооноороо байгаа навчсын завсраар гэрэлтэж байна. Фродо сайн гэгч суниагаад амьд оромжоосоо ухасхийн гарав.

Сэм ойн чөлөөнд өвсөн дээр сууж байна. Пин тэнгэр өөд харж өнөөдрийн цаг агаарыг шинжиж байна. Эльфүүд яваад өгчээ.

- Бидэнд жимс, ундаа, талх үлдээсэн байна. өглөөний цайгаа ууцгаа, шинэхэн талх байна. Бид хоёр чамайг босохыг хүлээлгүй бүгдийг нь идчихсэн, Сэм бөөлжиж байна - гэж Пин өглөөний шинэ мэдээ дуулгав. Фродо Сэмийн дэргэд суугаад өглөөний зоогоо барилаа.

- Өнөөдөр бид яах вэ? – гэж Пин сонирхов.

- Забренди рүү аль болохоор хурдан – гэж Фродо хоёр завьжаа түнтийлгэн заглах зуураа хэлэв.

- Морьтнуудын хажуугаар уу?

- Хажуугаар нь ч юу юм бэ, тэдэнд харагдахгүйгээр гол хүрчихвэл сайн сан.

- Харальд чамд тэдний талаар ямар нэг юм ярьсан уу?

- Битүү, дугуу ганц нэг юм хэлсэн

- Тэд яагаад шиншлээд байгааг асуув уу?

- Бид хоёр дэлгэрэнгүй яриагүй – гэж ам дүүрэн хоолтой Фродо хариулав.

- Асуух хэрэгтэй байсан юм. Миний бодлоор энэ хамгийн чухал

- Хэрэв тийм бол Харальд чамд илүү үг хэлэхгүй байсан. Ер нь чи намайг тайван байлгаад өгөөч. Би хоол идэж байхдаа яримааргүй байж болно, юм бодмоор байж ч болно.

Хоол идэж байхдаа бодох гэж үү? Их юм бодож амжих байлгүй – гээд Пин биеийн чилээгээ гаргахаар босч явлаа. Фродо үнэхээр бодож байв. Энэ өглөө манан будангүй, маш цэлмэг тунгалаг өглөө байна, мөрдөж мөшгөхөд нэн тохиромжтой ... гэж тэр бодож суув. Гэтэл түүний энэ түгшүүрт бодлыг Пиний хашгирах дуун таслав. Тэр ойн чөлөөгөөр гүйж, баяр хөөртэй хашгирч байна.

“Энэ хоёрыг дагуулж яваад хэрэггүй. Хоббитаны нутгаар идэж уугаад явж байх нь хөгжилтэй зугаалга. Харин харийн газарт зовж зүдэрч, өлсөж цангаж явах ямар хэрэг байна. Энэ хоёрыг гуйсан ч дагуулж явахгүй. Сэмийг ч авч явахгүй...” гэж Фродо бодов.

Тэр Сэм рүү харахад цаадах нь асуусан харцаар хариуллаа.

- Яав Сэм, юундаа хараа вэ? Би Хоббитанаас явж байна шүү дээ, их хол явна, Балкад очоод нэг ч өнжихгүй.

- Тэгээд юу гэж, эзэн минь?

- Чи надтай явах гэж үү?

- Мэдээж.

- Энэ аюултай ажил аа Сэм, эргэж ирэх найдвар бараг л байхгүй.

- Тэд нар надад “Чи Фродог сайн харж хамгаалаарай, битгий орхиорой” гэж хэлсэн. Тэгэхэд нь би “Одоо орхино, харж бай” гэсэн. Дараа нь “Санаа бүү зов, би үүнтэй сар руу ч хамаагүй явна, харин энэ юу билээ дээ, хар морьгнууд замд тээглэвэл Скромби надтай үзэлцэх болно, сайнаа үзэхгүй бий вий” гэсэн чинь тэд инээлдээд байсан.

- Тэд гэж хэн юм бэ? Чи хэний тухай яриад байна?

- Тэд үү? Эльфүүд л байхгүй юу. Шөнө ярьсан юм. Тэд бүгдээрээ таны тухай бүгдийг мэдэж байна лээ. Хаашаа явж байгаа, яах гэж яваа гээд л. Би тэдэнтэй маргаагүй. Ямар гээчийн мундаг ард түмэн юм бэ!

- Тийм ээ, үнэхээр гайхамшигтай ард түмэн. За чи тэднийг ханатлаа харж авлаа. Чамд таалагдав уу?

- Юу ч гэмээр юм бэ дээ – гэж Сэм бодлогошронгуй хариулаад – тэдний яриа надад их таалагдсан. Ямар амьтад байх бол гэж тааж ядаад байсан юм. Тэгсэн чинь ямар ч биш байдаг байгаа. Балар эртнийх мөртөө цэл залуу, хөгжилтэй мөртөө гунигтай ч юм шиг, ёстой бүү мэд... Фродо Сэм рүү гайхан харав. Тэр нэг л хачин өөр болсон юм шиг. Түүний мэддэг Сэм Скромби биш өөр хүн ярьж байгаа юм шиг, харахад Сэм мөн, тэгсэн мөртөө царай нь ер бусын бодлогошронгуй.

- Чи нэгэнт тэд нарыг үзсэн юм чинь одоо Хоббитанаас яваад яах билээ?

- Намайг ойлгоорой эзэн минь, энэ шөнөөс хойш би нэг л өөр болчихлоо. Зам урт, харанхуй руу хөтөлнө, гэвч буцаж болохгүй. Эльфүүд, луунууд, уулс энээ тэрээ ч сайхан л байна... Би тэднийг үзэх гэж таныг дагаагүй. Би яах гэж яваа юм бэ? Би танд заавал хэрэг болно, гэхдээ энд, Хоббитанд биш..., би юун тухай ярьж байгааг та ойлгож байгаа бол ...

- Үгүй ээ, ойлгохгүй байна, Сэм минь. Гэхдээ Гэндалф надад сайн замын хань сонгосон шиг байна. За за, хамтдаа л явъя.

Фродо өглөөний хоолоо чимээгүйхэн зооглоод босч Пинийг дуудав. Пин гүйгээд ирэхэд:

- Явах цаг боллоо. Оройтож бослоо, зам урт – гэв.

- Чи л өөрөө орой боссон байх, би аль эрт сэрсэн, бид хоёр чамайг идэж, бодож дуусахыг чинь л хүлээж байлаа – гэж Пин хариулав.

- Би дууслаа. Бид Зайгордын боомтод аль болохоор хурдан хүрэх хэрэгтэй. Гэхдээ замаар явахгүй, чигээрээ явна.

- Чигээрээ гэдэг чинь ниснэ гэсэн үг, явган явах зам байхгүй

Зам олно оо. Ойн харшаас зүүн тийш боомт байгаа, зам зүүн тийш муруйсан байна, тэр харж байна уу? Хойт талаас нь Их намгийг тойрч, Булангийн талаас далан руу орж байна. Энэ зам хэдэн бээр вэ? Чигээрээ явах юм бол дөрөвний нэгээр дөтөлнө.

- Их явбал холд хүрнэ гэдэг биз дээ, намаг л байдаг болохоос зам байдаггүй юм, би мэдэлгүй яах вэ дээ. Чи хар морьтнуудаас айж байгаа бол замаар явсан ч, ой дундуур явсан ч, талаар явсан ч ялгаагүй – гэж Пин эсэргүүцэв.

- Ойгоор юм уу, тариан талбайгаар явбал нуугдахад дөхөмтэй, биднийг зам дээр хүлээж байгаа, замгүй газраар биднийг хайхгүй – гэж Фродо хэлэхэд:

- За за, довон дээгүүр дамжиж харайгаад явна, чи түрүүлж, бид хоёр араас чинь явъя. Жаахан харамсалтай л байна. “Алтан тосгуур”-ыг хаахаас өмнө хүрч амжих байлаа, мөн ч сайхан пивотой шүү, энэ хавийн хамгийн сайн пиво, уулгүй удаж дээ – гэж Пин зөвшөөрөв.

- Тэгвэл маргаад байх юм алга, их явбал холд хүрнэ, пивоны мухлагт саатахгүй. “Алтан тосгуур”-ыг онилж байдаг, мөн онилох юм олов оо. Бид нар жаргахаас өмнө Балк орох хэрэгтэй байна. Сэм, чи юу гэж бодож байна?

- Би юу бодох вэ, таны хэлснийг л дагана – гэж Сэм хэлэхдээ Хоббитаны хамгийн сайн пивийг бодоод санаа алдав.

За ингээд намаг, өргөст бутан дундуур явахаар тохиролцлоо – гэж Пин яриаг дуусгав. Бараг өчигдрийнх шиг халуун, баруунаас гарсан үүл аадар бороо амлаж байлаа. Мань гурван хоббит өтгөн өвс ургасан эгц эрэг рүү бууж, бутан дунд орлоо. Тэд Ойн харшийн зүүн талаар ойг хөндлөн гатлаад уулын зүүн талыг арлан тал руу орох хэрэгтэй байв. Тэнд хүрсэн байхад суваг, хайснаас өөр саад болох юм байхгүй гэж Фродо тооцсон байлаа. Чигээрээ алхахад арван найман бээрээс илүү явахгүй гэж Фродо бодож байлаа. Холоос харахад бут тийм ч өтгөн биш юм шиг харагдаж байсан ч ороод ирэхээр маш өтгөн байв. Ямар ч зөрөг, жим байхгүй, таамгаар явж байв. өргөст бут зайгүй хучин ургасан шаварлаг эрэгтэй голд хүрлээ. Зам хаасан голыг гатлахын тулд норохоос гадна өргөсөнд хатгуулах, шаварт будагдахаас өөр замгүй байв.

- Муугүй эхэлж байна шүү - гэж Пин урамгүйхэн инээмсэглэв.

Сэм эргэж харахад ойт толгодын ногоон сэрвээ бутан завсраар харагдсаар байв.

- Хараач - гээд тэр Фродогийн ханцуйнаас татав. Эргэж харахад толгойн орой дээр хар морь,

дэргэд нь бөгтийсөн эзэн нь харагдав.

Буцах зам байхгүй тул Фродо түрүүлж шаварт эргийн бут руу гулсан буув.

- За харж байна уу! – гэж Фродо Пинд хэлээд - чи бид хоёр хоёулаа зөв бодсон байна. Чигээрээ явахад ойрхон биш боловч зам дээр саатсан бол бидэнд сайхан байх байжээ. Чи үнэг шиг сонор чихтэй шүү дээ Сэм, бидний араас хэн нэгэн гэтэж байна уу?

Тэд амьсгаа даран чагнахад араас гэтэх чимээ алга байв.

- Морь ийм эгц эрэг рүү бууж чадахгүй, гэвч энэ хорт могой биднийг ийшээ буусан гэж мэдэж байна. Түргэлцгээе!

Гэвч том үүргэвч үүрээд, өргөст бутан дундуур хурдан явах боломжгүй. өтгөн ой салхи хааж, бүгчим халуун нозооруулна. Арайхийн задгай газар гарч ирэхэд хөлс дуслан, хөлөө арай ядан зөөж, өргөсөнд зурсан мэт сараалуулж, дээрээс нь бас зүг чигээ алдсан байлаа. Гол задгай талд ирээд эрэг нь намсаж, өргөн, гүехэн болж, Их намаг, том мөрөн рүү эргэжээ.

- Хөөе, энэ чинь Сэлээ гол байна шүү дээ, хэрэв бид төлөвлөснөөрөө явъя гэвэл яг одоо гол гатлаад баруун тийш явах хэрэгтэй – гэж Пин хэлэв. Голыг гүехэн хэсгээр нь гаталж, эргийн зэгсийг тойрон тэгш талаар бүдэрч унан тусан шогшицгоов. Дараа нь дахиад ой руу орлоо. Газар тэгшхэн, хөлд тээглэх юмгүй боловч модод улам шигүү болж урдаа юу байгааг мэдэх аргагүй болов. Унасан навчсыг салхи шүүрдэн, бараан тэнгэрээс бороо дусаллаа. Тэгснээ салхи намдаж, аадар бороо асгарав. Мань гурав байдаг чадлаараа хурдалж, дов сондуул дамжин харайж, ноднин жилийн навчсын зузаан давхаргад шигдэн урагшилсаар, бороо асгарсаар. Таг дуугүй, байн байн эргэж харсаар, ийш тийш хараачилсаар явлаа. Хагас цаг орчим яваад Пин:

- Бид хэтэрхий баруун тийшилсэн учраас өмнө зүг рүү явж байх шиг байна. Аль хэдийн тариан талбайд орж ирэх болсон. Би энэ ойг мэднэ, өргөнөөрөө нэг бээрээс илүүгүй. Гэтэл бид яваад л байдаг, яваад л байдаг гэлээ.

- Одоо чиглэлээ өөрчлөхгүй, тэгвэл улам будилна. Явж л байвал болоо, би ил задгай газар гарахаас айж байна - гэж Фродо хэлэв.

Дахиад хагас цаг өнгөрлөө. Сиймхий үүлэн цаанаас нар гийж, бороо зогсов. Үд болж байхад өглөөнөөс хойш алхсан гурав өлсөлгүй яах билээ. Аянчид саглагар том нарс модны дор сууцгаав. Шарласан навчис нь унаагүй учир ёроолд нь хув хуурай байв. Эльфүүд тэдний дашмагийг мөнөөх алтлаг өнгөтэй, балын амтат сэнгэнэсэн сайхан ундаагаараа дүүргэжээ. Төдөлгүй тэр гурав ганц нэгхэнээр дуслах бороо, далимд нь бас хар морьтнуудыг шоолон инээлдэж суув. Одоо хэдхэн алхаад л хүрэх газраа хүрнэ.

Фродо нуруугаараа мод налаад нүдээ анилаа. Сэм, Пин хоёр хажууд нь хөлөө жийн суугаад аяархан дуулж эхлэв:

Нам гүмийг цочоож

Намбалаг дуугаа дуулья,

Салхин сар руу ульж л байг,

Саруул тэнгэр бүрхэж л байг.

Салхин ульж л байг,

Аадар асгарч л байг,

Аль нь ч байсан би урагшилна.

Даарч жихүүцэхгүйн тулд

Дашмаг руугаа өнгийе.

Дашмаг руугаа өнгийе – гэж чангахан давгсанаа нам болов.

Фродо ухасхийн бослоо. Салхи нэг жигтэйхэн урт, бие хөшим зэвүүн, өөдгүй улианыг хийсгэн ирж байлаа. Тэр муухай улиан цэвдэг хүйтэн тачаадал тээн хөндийгөөс хөндийд дамжин мохоо өрөм мэт чих өрөмдөн байв. Мань гурав хөшсөн мэт хөдөлгөөнгүй сонсч байлаа: тэр улиантай залган тэртээ алсаас яг түүн шиг зэвүүн хүйтэн өөр нэг улиан хариулаад нам гүм боллоо.

- Хачин орилоон байна шүү, тийм ээ. Шувуу л байх. Гэвч би Хоббитанд ийм хачин шувууны дуу сонсоогүй л юм байна – гэж Пин зориуд цовоо дуугаар хэлсэн боловч хоолой нь үл мэдэг чичирч байв.

- Шувуу ч биш, араатан ч биш – гэж Фродо хариулаад – Нэг нь дуудсан, нөгөө нь хариулсан, энэ улианд үг ч байсан, даанч зэвүүн, ойлгомжгүй юм. Харийн хэл байна гэв.

Дахиад энэ сэдвээр ярилцсангүй. Бүгдийнх нь толгойд хар морьтнууд байсан боловч тэр талаар дуугүй байсан нь дээр гэдгийг бүгд ойлгожээ. Явах аюултай, нуугдах бүр ч аюултай, гэвч боомтод хүрэхийн тулд, тэхдээ бүр гэрэлтэйд хүрэхийн тулд явах хэрэгтэй, тэхдээ хурдан явах хэрэгтэй байв. Гурвуул үүргэвчээ мөрөн дээрээ тавиад яаран шогшицгоов.

Төдөлгүй ойгоос гарч, өргөн нуга руу оров. Тэд үнэхээр хэтэрхий урд зүгийг барьсан нь илэрхий. Тэртээ зүүн талд тэгш талын цаана Брендидиумын нөгөө талд Хэлтгий уул бүдэг бадаг харагдана. Мань гурав ойгоос мөлхөх шахам тонгойн гарч, нуга дундуур гүйлээ.

Эхэндээ ойн хаалтгүй ил явах аймаар байлаа. Тээр хойно өглөөний цайгаа уусан ойт уул сүндэрлэнэ. Фродо цэг мэт жижигхэн хөдөлгөөнгүй морьтон харагдах нь уу гэж бодоод эргэж харлаа. Морьтон байсангүй. Нар үүлсийн хормойг шарж, тэгш талыг хурц туяагаараа гийгүүлэнхэн тэнгэрийн хаяан дахь толгодын цаагуур орлоо. Айдас алга болсон ч уйтгарт итгэлгүй байдал нэмэгдсээр. Эндхийн газар онгон зэлүүд биш, хадсан өвс, бухал харагдана. Тэгсгээд хаалгатай хайснууд, тариа ногооны талбай, усалгааны шуудуу үргэлжлэв. Бүх юм танил, найдвартай, амгалан тайван, ердийн л Хоббитан орон. Аянчид алхах тусмаа тайвширч

байв. Гол бүр ойрхон, хар морьтнууд хаа нэгтээ ард ойн хий үзэгдэл болж хоцорсон.

Сэтгэл гаргаж арчилсан ногооны талбайн захаар гарч, тэгшхэн шургааган хашаанд тулж ирэв. өргөн хаалганы цаана тэгшхэн зам зурайж, холгүйхэн бяцхан төгөл, цаана нь байшин байна. Пин зогсоод:

- Энэ хэний эдлэн болохыг би мэдэж байна, энэ бол Зожигийн суурин гэхэд Фродо:

- Чонын амнаас барын ам руу! – гээд лууны ичээнд санамсаргүй тулаад ирчихсэн мэт ухрав. Сэм, Пин хоёр түүнийг гайхан харав.

- Хөгшин Зожиг чамд юугаараа таалагддаггүй билээ? Тэр бол бүх Брендизайкуудын найз. Тэнэмэлүүдэд хэзээний дургүй, аймаар зуудаг ноходтой. Хил хязгаар нутаг болохоор аргагүй шүү дээ. Энд маш анхааралтай явах хэрэгтэй – гэж Пин хэлэв.

- Тэр ч яахав, би Зожиг болон түүний нохдоос айж байна. Багадаа их айдаг байсан юм. Би байн байн мөөгөнд явдаг, юм л бол баригдчихна. Сүүлийн удаа тэр намайг сайн гэгч торлогдоод, шилэн хүзүүн дээрээс барьж байгаад нохдодоо хандан “Энэ зулбасыг харж байна уу, дахиад ирвэл юутай хүүтэй нь идчихээрэй, би зөвшөөрч байна, харин одоо үдэж гарга” гэлээ. Гэтэл нохойнууд нь намайг бүр боомт хүртэл дагасан шүү! Ёстой үнхэлцэг хагарах шахсан: ноход юу хийхээ мэдэж байсан, араас дагаад л, архираад л. Гэхдээ ид гэсэн тушаал өгөөгүй болохоор надад хүрээгүй л дээ.

Пин тачигнатал хөхрөв:

- За учраа ол доо. Чи энд амьдрах гэсэн биз дээ. Зожиг бол жинхэнэ эр хүн, мөөгийг нь хулгайлахгүй бол яах ч үгүй. Хаалганаас шууд чигээрээ явъя. Бид тэнэмэлүүд биш гэдгийг хараг. Гараад ирэхээр нь би ярина шүү. Тэр Мерритэй их найз, би ч гэсэн хэл амаа ололцоод байдаг юм.

Аянчид явган замаар алхсаар төдөлгүй эдлэнгийн байшингуудын зэгсэн дээврүүдийг харав. Маш бат бэх, аятайхан тоосгон байшинг тойруулан царсан хаалгатай өндөр хашаа барьжээ.

Хаалганы цаана ноход дуу дуугаа авалцан хуцаж, “Соёо!, Чоно! Шонхор ! Над дээр!” гэх дуу хадав.

Фродо, Сэм хоёр дороо нам зогсч, Пин дахиад хэд алхав. Хаалга хагас нээгдэж, лужир том гурван нохой тэдэн рүү сүртэй чанга хуцалдан дайрав. Ноход Пинийг огт тоосонгүй, хоёр нь Сэм рүү дайрч, хашаанд шахаж байгаад баахан үнэрлэв. Гурав дахь нь буюу харваас хамгийн галзуу нь бололтой асар том нохой Фродогийн өмнө зогсоод нүд салгалгүй ажиглан аярхан архирна.

Хаалгаар намхан, бүдүүн, улаан царайтай хоббит гарч ирэв.

- Сайн байцгаана уу! Та нар хэн бэ, юу хэрэгтэй вэ? – гэж тэр асуулаа.

- Сайн байна уу Зожиг гуай! – гэж Пин мэндлэхэд тэр нэг сайн харснаа:

- Хүүе, Пин байна шүү дээ, ноён Перегрин Молтогчин! – гээд Зожиг маасайтал инээж - Уулзаагүй удаж шүү. Хуучин танил байсан минь яамай, тэгээгүй бол би нохойнуудаа тавих гэж байсан юм. Элдвийн тэнэмэлүүд зөндөө, өнөөдөр бүр ч олон байна. Голд дэндүү ойрхон – гээд толгойгоо сэгсэрч - за тэр этгээд чинь хаанаас гараад ирсэн юм бүү мэд, ямар янзын мануухай вэ? Дараачийн удаа яасан ч оруулахгүй. Хэдэн ясаа тараасан ч оруулахгүй дээ.

- Та хэний тухай яриад байна аа?

- Яагаав, та нарын урдаас явсан шүү дээ. Та нар яагаад зөрчихдөг байна? – гэж Зожиг гайхаад - ёрын муухай амьтан гэж би хэлээд байна шүү дээ, хачин хачин юм асууна... Байшинд орооч дээ, тухтай ярья. Би яг пиво чаначихаад сууж байна.

Ирсэн этгээдийн тухай яаралгүй, дэлгэрэнгүй ярих гээд тэсч ядаж байгаа бололтой.

- Ноход яах вэ? – гэж Фродо асуув.

- Би тушаагаагүй байхад ноход та нарыг яах ч үгүй – гээд эзэн инээж: -Хөөе! Соёо ! Шонхор ! Хэвтээд! Чоно! Хэвтээд!- гэж командлав.

- Энэ бол ноён Фродо Торбинс – гэж Пин танилцуулаад – та түүнийг танихгүй байгаа байх, энд амьдардаг байсан юм гэлээ.

“Торбинс” гэж хэлэнгүүт Зожиг ихэд гайхан Фродог нүд цавчилгүй харав. Нөгөөдөх нь “мөөгний хулгайг саначих шиг боллоо, одоо нохойнуудаа тавина” гэж бодов. Гэвч эзэн түүний гараас хөтөллөө.

- Мөн ч сонин юм болох нь дээ! Хараач хөөе, хоббитын тухай ярьтал хоббит ороод ирэв гэдэг л болж байна даа. Орцгоо орцгоо, ярих юм байна.

Бүгдээрээ том задгай зуух тойрон суув. Эзэгтэй торхтой пиво авчраад дөрвөн гүрүүшгэнд аягаллаа. Маш сайхан пиво байсан тул Пин “Алтан тосгуур” гэж хэлсэндээ ичиж байв. Сэм эндхийнхэн юугаар ч пиво хийдэг юм билээ. Хэдийгээр аль эрт болсон ч гэсэн эзнийг маань гомдоосон гэж бодоод болгоомжтой балгаж суув.

Цаг агаарын тухай, ургацын тухай (ерөнхийдөө муугүй гэнэ) ярьцгаав. Дараа нь гэрийн эзэн гүрүүшгээ ширээн дээр түсхийтэл тавиад зочдыг тойруулан харж:

- За ноён Перегрин, хаанаас хаа хүрч явна? Хэрэв манайх руу зорьж ирсэн бол арай л хажуугаар гараад явчихсангүй гэв.

- Танайхыг зорьж ирлээ, гэхдээ яг танайхыг ч арай биш, та тэртэй тэргүй таамаглаж байгаа юм чинь, үнэнээ хэлэхэд танайх руу санамсаргүй ороод ирлээ. Боомт орох гэж яваад ойд төөрчихсөн юм.

- Их яарч дээ, тэгээгүй бол замаараа явсан нь дээр байсан юм, гэхдээ тэрэнд гол нь биш, ноён Перегрин та нааш цааш явахдаа манайхаар санаа зоволгүй ирж бай, ноён Торбинс та ч гэсэн... Гэвч нөгөө мөөгний талаар юу гэж бодож байна? Бас л хуучнаараа юу? – гээд гэмгүй

сайхан инээж:

- Торбинсын Фродо хүүг сайн санаж байна. Мөн ч сүрхий дээрэмчин байсан даа, овгийг чинь мартсан байсныг сая санууллаа. өнөөдрийн ирдэг тэр хачин амьтан юу асуугаад байсан бэ?

Мань гурав цааш юу ярихыг нь тэсч ядан хүлээж байв.

- Нэг тийм хар морьтой юм. Пад хар, хамаг хувцас нь хар, нүүр нь ч харагдахгүй, таньчихна гэж айж байгаа юм шиг. Хаалга түгжээгүй байсан юм, орж ирэх гэж зүтгээд. Би бодлоо: “Ямар хачин амьтан бэ, манай Хоббитанд юугаа хийх гэж ирсэн юм бол? Хил ойрхон, есөн жорын юм тэнэж явдаг боловч ийм амьтныг энэ насандаа үзээгүй”. Урдаас нь гараад очлоо. “За сайн уу? Юу болоо вэ? Таны ирэх газар энэ биш, эргээд зам руугаа яв” гэлээ.

Тэр надад тун ч таалагдсангүй, Шонхор гүйж очоод үнэрлэснээ сүүлээ хавчаад гийнаад байх юм. Нөгөө хар чинь морин дээрээ хөдлөх ч үгүй суугаад л байх юм. “Би их холоос явж байна” гэж хэлэх нь хоолойгүй юм шиг хачин бөглүү дуутай. Миний газрын дээгүүр баруун тийш заагаад “Торбинсынхон энд байна уу?” гэж асуух юм. өөрөө шуухитнаад, над руу хазайгаад байх юм. Нүүр байхгүй, малгай дор нь хоосон нүх. Би айсандаа чичирч эхэлсэн. Чичрэх ч яах вэ, тэр уриагүй байхад юунд наашаа зүтгэдэг байна?

“Эндээс хурдан тонил! - Юуны чинь Торбинсынхон! Буруу газар ирчихэж. Тэд чинь Норгордод байдаг юм. Буцаад яв, харин миний газар дээгүүр явахгүй шүү, замаар яв” гэлээ.

“Торбинс тэнд байхгүй” – гэж шивнэж байна. Шивнэх нь исгэрэх шиг сийгээд л. “Торбинс наашаа ирсэн. Энд ойрхон байгаа, үзэгдэхээр нь надад хэлээрэй, алт авчирч өгнө” гэж байна.

“Авчир авчир, харин надад л биш шүү. Эсэн мэнд дээрээ тонил! Нохой тавина шүү” гэлээ. Тэр дооглож байгаа юм шиг шуухитнаад намайг мориороо дайрах гэсэн шүү. Би дөнгөж л зайлж амжсан, тэр морио давираад зам руу ухасхийсэн. Тэгээд л алга болсон... та нар хаашаа явж байгаа юм бэ?

Фродо гал руу хараад “Яаж боомт хүрэх вэ?” гэж бодож суув.

- Танд юу гэж хэлэхээ мэдэхгүй байна – гэж түгдрэв.

Мэдэхгүй бол хүн юу хэлэхийг сонсч бай. Ээ дээ, ноён Фродо минь дээ, ноён Фродо минь, яах гэж Норгорд явсан юм бэ дээ? Тэндхийн ардууд тэнэг. (Сэм суудал дээрээ хавчганаж, Зожиг руу муухай харав). Та нар дандаа ийм байдаг, эхлээд бодож, зөвлөлдөх хэрэгтэй байдаг юм шүү дээ. Та өөрийн шууд төрөл Брендизайкуудаас холдож, бүл өвөөгийн дөө очсон гэж би дуулсан. Тэгэхээр сайн юм болохгүй нь мэдээж. Хөгшин Бильбогийн чанасан бантанг та уух болж дээ. Тэр эд баялгийг алс газарт ариун хөдөлмөрөөр олоогүй. Одоо тэр Норгордод хэний ямар эрдэнэсийг нуусан бэ гэж тархиа гашилгадаг этгээдүүд гарч ирсэн.

Фродо дуугарсангүй. Ухаалаг Зожиг яг голыг нь олоод хэлчихлээ.

- Тэгэхээр ноён Фродо, та төрөлх нутагтаа эргэж ирэх ухаантай байгаа чинь сайн хэрэг. Сайн

зөвлөгөө сонс: нам гүмхэн амьдар, харийнхантай хэл амаар бүү холбогд. Танд энд найз нөхөд хангалттай бий. Тэр хар дахиад хүрээд ирвэл би учрыг нь олно. Сонирхож байвал хэлье. Таныг Хоббитанаас бүрмөсөн явсан, үхсэн гэж хэлнэ. Тэд таныг ангуучилж байгаа юм биш, ноён Бильбог ангуучилж байгаа юм. Яах гэж овгоо сольдог байна даа, хэрэггүй байсан юм.

Тийм нь ч тийм байх шүү- гэж Фродо гал руу гөлөрсөн хэвээрээ хэлэв.

Зожиг түүн рүү бодлогошронгуй харлаа.

- Та өөрийнхөө толгойгоор амьдрахыг хүсч байгааг чинь би харж байна. Цаг нь болсон. Та тэр харын талаар надаас илүү мэддэг юм байна. Миний яриа таныг гайхуулсангүй. Мэдэж байгаа бол өөртөө л хадгал, би сониуч хүн биш. Таны сэтгэл тавгүй байх шиг байна. Яасхийгээд боомт руу үзэгдэж харагдалгүй хүрэх вэ гэж бодож байна. Тийм үү?

- Тэгж л бодож сууна. Бодоод байх ч юу байхав, явах л хэрэгтэй байна, юу л болбол болог. Таны сайхан сэтгэлд их баярлалаа. Би танаас болон таны нохойнуудаас гучин жил айж явлаа. Тэнэгтээ л тэр байхгүй юу, та миний итгэлт анд минь байх байжээ. Танайхаас гараад явах харамсалтай л байна. Дахиад уулзах ч юм билүү, тэгвэл сайхан сууна аа.

- Тэгээрэй, гуйж байна. Харин одоо аан гэж бай! Нар жаргаж байна, бид оройн хоолоо идэх боллоо, манайх өглөөн нарнаар босч, оройн нарнаас унтдаг юм. Бидэнтэй оройн зоог бариач!

- Их баярлалаа, бид удаж болохгүй. Шөнө болохоос өмнөхөн гарам хүрчих байх.

- Үг ч хэлэхийн завдалгүй л яарч тачигнаад байх юм. Би юу гэх гээд байна вэ гэвэл, оройн хоол идчих, надад бүхээгтэй тэрэг байгаа, би та гурвыг хүргээд өгнө. Хурднаас гадна найдвартай, тэгэхгүй бол юу ч болохыг хэн байг гэхэв.

Энэ үг шийдвэрийг өөрчилж Фродо зөвшөөрөн дагуулуудынхаа санааг амраав. Нар бараг шингэж, бүрэнхий өтгөрч байлаа. Зожиг өвгөний хоёр хүү, гурван охин нь ирэв. Асар том ширээг тэр дор нь идэж уух юмаар бүтээж, оройн зоог арав гаруй зочинд ч хүрэлцэхээр элбэг байв. Лаа барьж, задгай зуух асаалаа. Пиво хичнээн ч уусан хүрэлцэхээр, үндсэн зоог – гахайн махтай дарсан мөөгийг бүгдийг нь идэцгээв. Ноход галын дэргэд хэвгээд яс мэрнэ. Оройн хоолны дараа Зожиг хөвгүүдтэйгээ дэнлүү аван гарч тэргээ бэлтгэв. Зочид гарч ирэхэд хашаан дотор харанхуй байлаа. Аянчид үүргэвчээ тэргэнд оруулаад өөрсдөө тухлан суулаа. Зожиг түхийтэл таргалсан хоёр понийн жолоог дугтран хөдлөхөд эхнэр нь гэрэлтэй хаалганы дэргэд зогсч үлдлээ:

- Чи өөрөө болгоомжтой яваарай! Харийнхантай түг таг хийсний хэрэггүй, хүргэж өгөөд л шууд эргээд ир!- гэж эхнэр нь араас хашгирав.

- За за – гэж өвгөн хэлээд тэрэг хаалгаар гарлаа. Огтхон ч салхигүй мөртөө сэрүүхэн, аниргүй намуухан шөнө. Гэрэлгүй, аажуухан явж эхлээд замаар далан хүрч тэндээс цааш далан дээгүүр явав. Замын уулзвар дээр очоод Зожиг тэрэгнээс бууж ийш тийш хараачлав. Тас харанхуй, ямар ч анир чимээгүй байлаа. Голын манан цөөрөм дээгүүр өтгөрөөд тариан талбайнуудаар таран мөлхөнө.

Мөн ч харанхуй байх чинь, буцахдаа гэрэл асаана аа, одоо ч яахав – гэж Зожиг хэлэв. Боомт хүртэл таван бээр гаруй үлджээ. Хоббитууд цуваа нөмрөн сууж, зөвхөн дугуйн чихрах, туурайн топ топ хийх чимээ л сонсдоно. Пин үүрэглэж, Сэм манан руу сэрэмжлэн харж явна.

Эцэст нь баруун талаас хоёр өндөр багана цайран харагдах нь боомт руу эргэх эргэлт ажээ. Зожиг жолоогоо татахад тэрэг эргэлтэн дээр түр зогсосхийгээд уул руу буув. Дахиад нам гүм болсноо... сонсохоос айж байсан нөгөөх туурайн чимээ бүгдэд тод сонсогдлоо. Тэр голын талаас ойртож байв.

Зожиг тэрэгнээс үсрэн бууж, морьдоо тургихаас сэрэмжлэн хүзүүнээс нь бариад харанхуй руу ширтэв. Үдшийн аниргүй агаарт топ топ цохилох туурайн төвөргөөн тов тод сонсдоно.

- Та нуугдсан нь дээр байх аа, эзэн минь – гэж Сэм яаран зөвлөв. – Тэрэгний ёроолд хэвтээд элдэв юмаар хуччих, бид энэ морьтонг яаж ийгээд аргална – гээд тэр үсрэн бууж Зожигийн дэргэд зогсов. Морьтнууд бол морьтнууд л биз, гэхдээ эхлээд намайг дэвсэлнэ биз гэж тэр бодлоо.

Топ- топ, топ- топ. Одоо дээрээс бууна.

- Хөөе – гэж Зожиг сөөнгө хоолойгоор хашгирахад туурайн чимээ нам болов.

Хэдхэн алхмын цаана морь унасан цувтай дүрс тодорлоо.

- Зогс! гэж Зожиг тушаалаа. Тэр жолоогоо Сэмд өгөөд урагш алхаж:

- Наанаа зогсч бай! Чамд юу хэрэгтэй вэ? Хаашаа явж байна?

- Би ноён Торбинсын араас явж байна. Тэр тантай тааралдаагүй биз? – гэж тун ч танил дуу бөглүүхэн сонсдов... Мэдээж Мерри Брендизайк. Цуван дотроосоо дэнлүү гаргаж, гайхсан Зожигийн нүүрийг гэрэлтүүллээ.

- Ноён Мерри! – гэж Зожиг дуу алдав.

- Тэр чинь л байна. Та хэн гэж бодоо вэ? – гэж Мерри манан дотроос жолоогоо сэгсэрсээр гарч ирлээ.

Айдас оргүй алга болов. Тэдний өмнө зузаан ороолт ороосон, пони унасан ганц хоббит зогсч байна.

Фродо тэрэгнээс бууж, урдаас нь очлоо.

- Оргодлууд олдлоо – гэж Мерри хөгжилтэй хэлээд – та нарыг хаа нэгтээ саатаад оройн хоолонд амжихгүй нь гэж бодлоо. Ядаж манан хөөрчихлөө. Би жалгануудыг харж яваа юм. Та нар өнхрөөд орчихвол хэн гаргаж ирэх юм бэ? Тийм юм болдог л юм. Ноён Зожиг та эднийг хаанаас олов? Нугасны цөөрөмд сэлж явна уу?

- Зүгээр л буруу замаар орчихож. Би эд нар руу золтой л нохой тавьчихсангүй, өөрсдөө ярина

биз дээ. Харин одоо уучлаарай ноён Мерри, ноён Фродо болон бусад нь. Эхнэр санаа зовж байгаа, одоо харилгүй горьгүй, ямар ч харанхуй шөнө вэ – гээд тэр тэргээ ухрааж эргүүлэв.

- Бүгдээрээ сайхан нойрсоорой! Мөн ч сонин өдөр байлаа даа, хүнд яриад үнэмшихгүй. За за, төгсгөл сайн бол бүх юм сайн. Та нар бас нэлээн явна, би ч гэсэн. Уулзацгаах байлгүй дээ.

Тэр дэнлүүгээ асаагаад суудал дороосоо том сагстай юм гаргаж ирэв.

- Мартчих шахлаа байна, эхнэр маань юухан хээхэн өгсөн юм, хэрэг болно, ноён Торбинст онцгойлон өгч байгаа юм.

Тэд гүн шөнө рүү түргэн далд орж байгаа бүдэг гэрлийг харцаараа үдэв. Фродо гэнэт инээв. Сайтар тагласан сагсан дотроос шарсан мөөгний сайхан үнэр гарч байлаа.

Бүлэг 5

Илэрсэн хуйвалдаан

Бид ч гэсэн яаралгүй болохгүй. Та нарт тоглох цаг алга байгааг харж байна, очоод ярилцъя – гэж Мерри хэлэв.

Дөрвөн хоббит тэгшхэн, индүүдсэн том том цагаан чулуугаар хашсан замаар доош буув. Хэдхэн зуун алхам яваад тэд гол хүрч, уужуухан зогсоол дээр очиход дэргэд нь том модон гаталга онгоц долгионы аясаар найгаж байлаа. Өндөр шон дээрх хоёр гэрэл зогсоолын талбайг гэрэлтүүлж байлаа. Эрэг өөд цайвар манан мөлхөж байсан ч голын ус тас хар, зөвхөн зэгсэн дунд сүүн өнгөт манан цайрна. Голын цаана манан шингэрчээ.

Мерри гаталга онгоцны гүүрээр понигоо хөтлөн бусад нь араас нь гарлаа. Мерри урт модоор яаралгүйхэн түлхэхэд онгоц, зогсоол хоёрын хоорондуур Брендидиум голын дөлгөөн урсгал мэлтэлзэв. Зүүн эрэг эгц бөгөөд муруй тахир замын дэнлүүнүүд яралзаж, Ташуу уулан дээр Брендизайкуудын эртний эдлэн газар – Хоромин-у-Брендидиумын байшингуудын улаан, шар гэрлүүд сүүмэлзэнэ.

Эрт цагт Их намаг болон Хоббитаны хамгийн эртний омгийн тэргүүн Зовлонт Побегайк Хоббитаны зүүн хил байсан энэ голыг гатлан суурин байгуулж, бараг тусгаар тогтносон энэ хязгаарын захирагч Побегайка Брендизайк болжээ. Үр ач нар нь өнөр өтгөн өсч, өөрөө ч олон жил удирдаж, орон байшингууд нь уулын бэлийг бүхэлд нь эзэлж, Хоромин гурван тансаг орц, маш олон хаалга, зуу орчим цонхтой болжээ. Брендизайкийнхан болон олон төрөл садангууд нь эхлээд ухаж, дараа нь барьсаар тойргийг нэлд нь барилгажуулсан байна. Хоромины тулгын чулууг тавьснаар Забрэндийн түүх эхэлж, мөрөн гол болон Мөнхийн ойн хоорондох зурвас газарт Хоббитаны бараг тусгаар тогтносон, хүн ам олонтой муж болжээ. Хоромины цаадах толгодод бөөгнөрсөн эндхийн гол сууринг Зайгорд гэж нэрлэжээ.

Их намгийн оршин суугчид брендизайкуудтай нөхөрлөж, Хоромины захирагчийн эрхийг Булангаас Зэгст хүртэлх бүх суурингийнхан бүгд хүлээн зөвшөөрсөн байна. Гэвч хуучны сайхан Хоббитанд Туулайн толгодынхныг харийнхан гэхгүй ч гэсэн хачингийнхан гэдэг байв. Эрүүл саруулаар сэтгэх юм бол тэд бусад дөрвөн тойргийн хоббитуудаас тун ч бага ялгаатай. Завиар сэлэх, зарим нь бүр завь ч үгүй сэлэх дуртайг нь эс тооцвол бараг ялгаагүй.

Дорно зүгээс ямар ч хаалт хамгаалалт байгаагүй боловч хожим нь брендизайкууд өндөр хашаа барьж, түүнийгээ Хамгаалалтын ханан тулаан хэмээн нэрлэсэн ба аль эрт цагт барьсан энэ хэрэм жилээс жилд өндрөөшөө ч, өргөнөөрөө ч тэлсээр байв. Энэ хэрэм Брендидуимийн гүүрнээс Бургаст хүртэл хорин бээр гаруй нумран үргэлжилдэг. Хамгаалах нь хамгаалдаг боловч тийм ч сайн хамгаалдаггүй аж. Ой хэрэм рүү улам л түрж, Забрэндид шөнийн цагаар хаалгануудаа түгждэг боловч хоббитанчууд үүнд итгэхийг ч хүсдэггүй байв.

Гаталга онгоц харийн эрэг рүү чимээгүйхэн хөвж байлаа. Сэмээс бусдад гаталга онгоц шинэ сонин зүйл биш бөгөөд голын урсгал түүнийг манан дунд үлдсэн өмнөх амьдралаас нь зааглаж, өмнө нь үл мэдэх харанхуй ангал байгаа юм шиг санагдаж байлаа. Тэр шилэн

хүзүүгээ маажиж, “Байж сууж чадаагүй л юм байх даа, амьдардгаараа амьдраад байж болох л байсан” гэж бодов.

Хоббитууд онгоцоос харайн бууж, Мерри онгоцыг аргамжин, Пин пониг жимээр хөтөлж, Сэм Хоббитан руу сүүлчийн удаа эргэж хараад сөөнгө дуугаар

- Хараач эзэн минь, надад тэгж санагдаад байгаа юм болов уу? –гэв.

Нөгөө эргийн зогсоол дээр дэнлүүнүүдийн бүдэгхэн гэрэлд ямар нэг юм – амьд хар шуудай гарч ирээд мөлхөж, зогсоолыг үнэрлэж байх шиг харагдсанаа арагш ухарч харанхуйд далд оров.

- Хоббитанд юун сонин юм гараад ирэх нь энэ вэ? гэж Мерри нүдээ бүлтийлгэн гайхав.

- Бидний мөрөөр мөшгиж яваа юм. Дахиад битгий асуу, хурдалъя – гэв. Тэд жимээр дээш гүйж гараад манант эрэг рүү харсан боловч юу ч олж харсангүй.

- Баруун эрэгт өөр завь байгаагүй нь яамай, мориор сэлээд гарч болох болов уу? гэж Фродо асуув.

- Брендидиумын гүүр хүртэл хориод бээр зайтай, сэлээд гарч чадахгүй биз дээ. Энэ голыг мориор сэлээд гарч байсан тухай би амьдралдаа сонсоо ч үгүй юм байна. Тэр морьтон чинь хэн юм бэ? – гэж Мерри асуултаар хариулав.

- Дараа хэлье, хаалгаа түгжсэний дараа.

- Дараа бол дараа л биз. Пин, та хоёр зам мэднэ, би понигоо унаад Бүдүүн рүү очлоо. Та нарт оройн хоол өгөх хэрэгтэй.

Бид ч уул нь Зожигийнд оройн хоолоо идчихсэн л дээ, гэхдээ дахиад идсэн ч чадна.

- Ёстой ховдогууд юм даа, наад сагсаа өгөөдөх – гээд Мерри харанхуйд уусав.

Молтогчингийн судаг хүртэл тийм ч ойрхон биш байв. Тэд зүүн талдаа Хоромин бүхий Ташуу уулыг орхиод Брендидиумын гүүрнээс өмнө зүг рүү чиглэсэн гол замаар орлоо. Гүүр рүү чиглэн хагас бээр яваад баруун тийш эргэж, нарийн зөргөөр дахин нэг бээр яваад сэргэр хашааны нарийхан хаалганд тулж ирэв. Замаас зайдуу газарт жижигхэн дугариг цонхнуудтай, том дугариг хаалгатай, сүрлэн дээвэртэй, намхан урт байшин байна.

Хашааны хаалганаас зөөлөн ногоон зөргөөр байшин руу явахад цонхны цаанаас өчүүхэн ч гэрэл харагдсангүй. Фродо хаалга тогшиход Бүдүүн Минж хаалга нээж, доторхи гэрэл үүдний довжоог гэрэлтүүлэв. Тэд дотогш орж, бүх түгжээг түгжээд хоёр талдаа хаалгатай нэлээд уужим үүдний танхимд орлоо. Доторх коридороос Мерри гарч ирлээ.

- За юу гэмээр байна даа? Бид хоёр яаруу сандруу ч гэсэн бүгдээрээ гэртээ байгаа юм шиг байлгахын тулд байдгаараа хичээсэн. өчигдөр орой л ирсэн шүү дээ. Мөн ч замбараагүй байсан даа.

Фродо эргэн тойрноо харав. Үнэхээр гэртээ байгаа юм шиг санагдаж байна. өөрийнх нь дуртай эдлэлүүд, Бильбогийн дуртай тавилгууд ч байр байрандаа байна. Яг л Уутан хясаанд байгаа юм шиг. Аятайхан, тохитой, тайван. Энд л үлдэж үлдсэн насаа өнгөрөөх юмсан гэж тэр туйлаас хүсэв. Найз нар нь түүний төлөө ингэж их хичээсэн байна... Фродо дахиад л айх шиг болж, “Эдэнд би одоо, үгүй ээ маргааш явна гэдгээ яаж тайлбарлах вэ, хойш тавилгүй одоо тайлбарлах хэрэгтэй” гэж бодлоо. Тэр шүлсээ залгиад:

- Гайхалтай, гэрээсээ хаашаа ч яваагүй юм шиг! – гэж дуу алдав.

Үүргэвчүүдээ тавьж, цувнуудаа өлгөөд Мерри тэднийг дагуулан коридороор явж нөгөө талын үзүүрт байгаа хаалгыг нээв. Тэр тасалгаанд гал улалзаж, халуун уур ханхийв.

- Саун гэж үү дээ? Мерри чи ч мундаг юм аа- гэж Пин баярлан дуу алдав.

- Хэн эхлэх вэ? Ахмад нь уу, хурдан нь уу? Перегрин эзэнтэн минь чи аль ч тохиолдолд хоёр дахь нь – гэж Фродо хэлэхэд Мерри:

- Больцгоо та нар! Шинэ байшиндаа шинэ амьдралаа угаалганаас эхлэх нь үү!- гэж цочоосноо – тэнд гурван хувин хүйтэн ус, нэг тогоо буцлам халуун ус байгаа. Бас хэрэг болж магадгүй: алчуур саван гээд бусад юм байгаа. Усалцгаа, угаацгаа, харин хурдлаарай гэж шавдуулав.

Мерри, Бүдүүн хоёр шөнийн зоогоо гүйцээж бэлтгэхээр гал зуух руу орлоо. Угаалгын өрөөнөөс дуу дуулах, хашгирах, ус цацах чимээ сонсдоно. Дараа нь Пиний дуу бусад бүх чимээг дарав. Тэр Бильбогийн дуртай сауны дууг байдаг хоолойгоороо дуулж байна:

Хөөе дуулаарай,

Халуун усаар цохиорой,

Хөлс хир, замын тоосоо

Хөөж алга болгоорой,

Хамгийн заваан, адгийн амьтад л

Халуун усны дууллыг өргөдөггүй!

Борог өвсний үндсийг ундаалдаг

Борооны горхины шулганаа амттай ч

Халуун усны халхай уур

Хамгийн сайхан хоолноос ч амттай!

Уур савсан халуун усаар

Өөрийн биеийг өвдтөл цохиход

Хөөсөрсөн пивоны нэгхэн балга

Уулын горхины уснаас ч амттай

Охидын бэлхүүс шиг энхрий гоо

Оргилуур ус тэнгэрийг үнсдэг ч

Хазах шахам халуун урсгал

Хайртай бүсгүйн үнсэлтээс ч амттай

Ус цацан шуугилдсанаа “Хөөе чи болгоомжтой гэм!” гэж Фродогийн хашгирах сонсдов.

Пин том хувин дүүрэн усыг бүгдийг нь толгой дээрээс асгасан бололтой. Мерри хаалган дээр очив:

- Заваанууд аа! Хоол идэж, пиво балгах юу болсон бэ?

Фродо үсээ самнасаар гарч ирлээ. Мерри хаалгаар шагайж:

- Өө за за, шалан дээр сэлж болох нь ээ? Энэ чиний бүтээл биз дээ эрхэм Перегрин? Хуурай болтол арччихаад гараад ир. Хоолноос хожимдвол заяа чинь тэр!

Гал тогоонд, том задгай зуухны дэргэдэх ширээнд сууцгааж хооллов.

- Мөөг идэж цадаа биз дээ? гэж Бүдүүн итгэл муутайхан асуухад:

- Цадталаа идлээ, дахиад иднэ – гэж Пин хашгирав.

- Мөөг минийх, ертөнцийн хамгийн сайн эзэгтэй бэлтгэсэн юм. Савраа тат, би өөрөө та нарт таваглаж өгнө.

Хоббитууд мөөгөнд маш дуртай. Тийм ч учраас Фродо багадаа Зожигийн хашаа руу ордог байжээ. Одоо мөөг хангалттай их байгаа, бас дээр нь идэх юм зөндөө байсан тул Бүдүүн Минж хүртэл нэлээд хүч гаргаж, санаа амарсан шинжтэй санаа алдав. Тэд ширээгээ холдуулж, зөөлөн сандал тавьж, галын дэргэд тухлав.

- Дараа угааж янзална – гэж Мерри хэлээд - За яриад байгаарай, та нар адал явдал хөөж явдаг, бид хоёр энд ажлаа дийлэхгүй байдаг, мөн таарав аа. Эхнээс нь эцэст нь хүртэл яриад бай, ялангуяа тэр Зожигийн тухай, тэр яачихсан юм бэ, галзуурчихсан юм уу? Би бүр маанагтчихлаа, тэр ямар нэг юмнаас айна гэж байдаг юм уу?

- Айхгүй байхын аргагүй л дээ – гэж Пин тааламжгүй нам гүмийг таслан хэлээд - чамайг яахыг чинь харах юмсан. Чи хаашаа хөдөлнө, хар морьтнууд араас чинь

- Юун хар морьтнууд билээ?

- Хар морь унасан хар юмнууд. Фродо ярих дургүй байгаа болохоор би ярьж байна.

Тэгээд тэр аяллынхаа тухай бүр Норгордоос эхлээд дуустал ярив. Сэм толгой дохиж, хааяа нэг ханиан яриаг нь дэмжиж, Фродо таг дуугүй суув.

- Би тэр бузар муухай юмыг зогсоол дээр байхыг нь өөрийн нүдээр хараагүй сэн бол, Зожигийн дууг сонсоогүй сэн бол энэ бүхнийг чиний зохиол гэж бодох байсан. Фродо чи юу гэмээр байна?

- Замын турш энэнээс нэг ч үг сонсч чадсангүй. Таг дуугүй байснаар юу хожих юм бэ? Зожиг хүртэл бүх гай зовлон Бильбо ахын баялгаас үүдэлтэй гэж таамаглаж байна лээ.

- Таамаглаж л байг, нарийн тодорхой юм тэр юу ч мэдэхгүй гэж Фродо бувгнав.

- Юу ч гэмээр юм, тэр бол их юм үзсэн, ухаантай өвгөн, хэлж байгаагаас нь хамаагүй их юм ухаанд нь байж л байгаа. Тэр цагтаа Мөнхийн ойгоор тэнэж явсан гэж ярьцгаадаг юм, ер нь мэдэхгүй юм гэж байхгүй. Фродо, чи ядаж тэр өвгөн зөв таамагласан уу хэл дээ!

- Яахав дээ, ... зарим нэг юмыг зөв тааж байна лээ. Энэ бүхэн Бильбогийн эртний паянтай холбоотой, хар морьтнууд түүнээс болоод л намайг мөшгөөд байгаа юм. Нэгэнт иймдээ тулсан болохоор бас нэг юм хэлэхэд энэ бол огт тоглоом биш, маш аюултай зүйл. Энэ байшин намайг хамгаалахгүй, надад нуугдах газар алга – гээд Фродо хана, цонхнууд яг одоо алга болох гэж байгаа юм шиг тойруулан харав. Гурван залуу хоббит учиртайхан харц солилцов.

- Эцсийн эцэст – гэж Пин шивнэхэд Фродо:

- Тийм ээ – гээд Фродо шийдэмгий босч - Хэлэх цаг боллоо. Та нарт дуулгах гунигт мэдээ байна, харин юунаас эхэлье дээ байз.

- Тийм бол би чиний өмнөөс эхэлье дээ – гэж Мерри тайван хэлэв.

- Чи миний өмнөөс ярих гэж үү? – гэж Фрод мэл гайхсан харц талбив.

- За тийм ээ, сонсч бай. Чиний зүрх сэтгэлд одоо хүнд байна. Шууд хагацах мэдээж хэцүү. Чи аль эрт Хоббитанаас явахаар шийдсэн боловч хойш тавьсаар байсан, гэтэл айхгар том гай гэтээд ирэхээр бодох ч завгүй болсон. Гараад явсан боловч цааш явах хүсэл алга. Бид чамайг маш их өрөвдөж байна.

Фродо амаа нээснээ үг хэлэлгүй хааж, маш их гайхсан байдалтай харсан тул бусад нь элгээ хөштөл инээлдэв.

- Фродо анд минь, чи биднийг юу ч мэдээгүй гэж бодож байгаа юм уу? Яалаа гэж дээ! Толгой чинь хүрэхгүй. Чи бүр дөрөвдүгээр сараас л аян замд бэлдсэн шүү дээ. Гадуур тэнээд л, “Хэзээ нэгэн цагт энэ хөндийг дахин харах болов уу” ч гэх шиг хачин хачин юм үглээд л. Аа бас мөнгө дуусч байна, аргагүйн эрхэнд Уутан хясааг худалдлаа, гэхдээ хэнд гээч!

Лякошелүүдэд!..

- Өө за за – гэж Фродо аялгуулан хэлээд – гэтэл би туйлын болгоомжтой, хамаг бодлоо нууж байна гэж бодож байдаг. Гэндальф энэ талаар юу гэж хэлэх байсан бол? Норгорд тэр аяараа чиний аяллын тухай ярьж байна гэх байсан даа.

- Тэнэг үг. Удаан хугацаагаар биш ч гэсэн одоохондоо чиний нууц зөвхөн хуйвалдагчид бидэнд л илэрхий байгаа. Бид чамайг арван хуруу шигээ мэднэ шүү дээ, ойлгож үз. Чи нэг юм бодож байхад тэр бодол чинь нүүрэн дээр чинь бичээстэй байдаг юм. Үнэнээ хэлэхэд Бильбог явснаас хойш чамайг нүд салгахгүй ажиглаж байсан, яагаад гэвэл хэсэг хугацааны дараа энэ нөхөр ч бас яваад өгнө гэж мэдэж байсан. Чамайг бидэнд мэдэгдэлгүй оргоод явчих вий гэж их айдаг байлаа. Хавар, зун бид чамаас нүд салгаагүй, бүгдийг цэгнэн бодоод шийдвэр гаргасан юм. Чи биднээс зүгээр нэг оргоод алга болохгүй шүү, найдах хэрэггүй!

- Одоо яая гэхэв, эрхэм андууд минь, та нарт хэцүү байна, надад бүр ч хэцүү байна, гэвч намайг ятгах гэсний хэрэггүй. Нэгэнт таамаглаж байгаа юм бол надад тусал, ядаж битгий саад бол.

- Үгүй ээ, чи ойлгосонгүй – гэж Пин хашгираад – Хэн чамайг явуулахгүй гэсэн юм бэ, яв. Харин Мерри бид хоёр яаж ийгээд чамаас хоцрохгүй. Сэм гайхамшигтай залуу, нуруу нь л хүрдэг юм бол чиний төлөө лууны амыг зад татна. Гэхдээ аялал маш аюултай болохоор чамд ганц дагуул цөөднө.

- Миний хайрт, эрхэм сайн хоббитууд минь – гээд Фродогийн хоолой чичирч - би үүнийг зөвшөөрч чадна гэж үү? Би ч гэсэн эртнээс сайтар бодоод шийдчихсэн. Аюултай аялал гэв үү? Түүнээс долоон дор. Энэ бол эрдэнэсийн эрэл биш, “Тийшээ ба буцах замд” гэдэг зугаалга биш. Үхэл бүх талаас, эргэлт бүрийн цаана отоож байгаа.

- Тайлбарлаж өгсөнд баярлалаа – гэж Мерри дооглонгуй хэлээд гэнэт дуугаа чангалж – Тийм учраас бид чамтай явна, бид энэ бөгж ямар аймшигтайг мэднэ, тэгээд л бид Дайсантай тэмцэхэд чинь чамд туслах гэсэн юм гэж тов тод хэлэв.

- Бөгж?! – гэж Фродо аянганд ниргүүлсэн мэт нэгэн хором ангайсны эцэст арайхийн дуугарав.

- Тийм ээ бөгж – гэж Мерри батлаад – Фродо чи найзуудаа усан тэнэг гэж боддог юм шиг байна. Би чиний бөгжний тухай өчнөөн олон жил, бүр Бильбогийн үеэс мэднэ. Нэгэнт тэр нууцлаад байсан болохоор би чалчаагүй юм. Бильбог би чамаас муу мэддэг байсан. Би өнөөгийнхөөсөө хамаагүй залуу байсан, тэр чамаас хамаагүй зальтай байсан. Гэхдээ л тэрэнд ч гэсэн сул тал байсан, ярих уу?

- Ярь ярь – гэж Фродо сулхан дуугарав.

- Тэр Лякошелиэс болж сул талаа харуулсан юм. Нэг удаа, найр болохоос өмнө би замаараа алхаж явтал миний өмнө Бильбо явж байлаа. Гэтэл Лякошель эхнэртэйгээ урдаас ирж явна. Бильбо сандарч ухарснаа гараа халаасандаа хийх шиг болсон чинь харсаар байтал алга

болчихов. Би гайхсандаа өөрөө ч нуугдахаа мартсан боловч гэнэт санаа аваад хашаан дээгүүр харайж, өвсөн дунд хэвтчихлээ. Нөгөө хоёр ч өнгөрөөд явлаа, хоосон зам дээр Бильбо тайван гэгч нь урган гарч ирээд халаас руугаа нэг гялалзсан алтлаг шар юм хийчихлээ.

Надад мэдээж сонин байлгүй яахав. Тэгээд л шууд тагнуулдаж эхэллээ. Та нар юу гэж бодно хамаагүй, би арван наймтайдаа тийм сониуч байсан юм. Фродо минь, би Хоббитан даяар Бильбогийн тэмдэглэлийг үзсэн чамаас өөр ганцхан хүн гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой.

- Бас тэмдэглэлийг нь үзсэн хэрэг үү!? Энэ чинь одоо юу болж байна! Юу ч нууц байж болохгүй юу?- гэж Фродо хашгирав.

- Яалаа гэж, нууц байлгүй яахав, гэхдээ бүгдээс нууж болохгүй. Тэр тэмдэглэлээ нүдний цөцгий мэт хямгаддаг байсан, би самбаачилж нэг нүднийхээ булангаар гялс харсан юм.

- Одоо тэр тэмдэглэл байгаа болов уу? Би нөгөө нүдээрээ нэг харах юмсан. Чамд одоо байхгүй биз?

- Байхгүй, Ууган хясаанд тэр тэмдэглэл алга байна лээ, өөрөө авсан биз.

- Би мэдэж авсан нууцаа энэ хавар хүртэл хадгалсан. Гай тулаад ирэхэд бид хуйвалдаан зохиож, хэн юу мэддэгээ ярьцгаасан юм. Чи Гэндальф шиг дуугүй боловч цаадах чинь долоон дор. Гэхдээ бидэнд гол тагнагч-чагнагч байсан, нуух юм алга, одоо бариад өгчихье.

- Заагаад өг, тэр хаана байна? – гээд Фродо яг одоо шүүгээн дотроос хар баг өмссөн хар тагнуулч гараад ирэх гэж байгаа юм шиг эргэн тойрноо сэжигтэйгээ харав.

- Сэм! Ичиж зовох хэрэггүй – гэж Мерри хэлэхэд Сэм босч, чихээ хүртэл улайчихсан, гараа унжуулан гэмшилтэйгээ доош харж зогсов.

- За, манай гол мэдээлэл ологч энэ байна даа! Тэр баригдах хүртлээ хангалттай их мэдээлэл цуглуулсан. Баригдсанаасаа хойш ус балгачихсан юм шиг болчихсон, үнэнч шударга нь саад болсон юм байлгүй.

Фродо зөвхөн -Сэм! – гэж дуу алдахаас өөр яаж ч чадсангүй. Инээх үү, уурлах уу, санаа амарч сайхан уужуу амьсгаа авах уу алийг нь ч мэдсэнгүй. Ийм тэнэг байдалд орсон хүн яах билээ.

- Эзэн минь, би танаас болж л, Гэндальфт би, ю.. у... л даа, тэр юу ч хэлдэггүй нь дэмий, тэр юу гэж хэлсэн гээч, та түүнд одоо явлаа гээд, тэр таныг найдвартай найзуудаа авч яв гээд...- гэж Сэм айсандаа үгээ эвлүүлж чадахгүй зогсов.

- Одоо би хэндээ найдах вэ дээ – гэж Фродо бувтнахад Сэм улам доош харав.

- Юугаа найдахаас л хамаарна даа, бид чамтай хамт гал ус руу аймшиггүй орно, үхэх цаг ирвэл хамтдаа үхнэ. Нууцыг чинь чамаас дутуугүй хадгална. Харин бид чамайг зөнд нь орхиод, чи ганцаараа явна гэдэгт бүү найд. Фродо минь, чи тэнэг юм даа. Бид чиний андууд шүү дээ. Энэ замд бид нүдэн балай чихэн дүлий гараагүй. Бид Гэндальфын чамд ярьсан бүхнийг мэднэ, бөгжний тухай ч мэднэ. Бидэнд их аймшигтай байна, гэсэн ч чамтай хамт

явна, дагуулж явахгүй байсан ч дагаад л явна гэж Мерри түс тас хэлэв.

- Өршөөгөөрэй эзэн минь, эльфүүд танд юу гэж зөвлөсөн билээ? Хэн хамт явахыг хүснэ, аваад л яв гэж Харальд хэлээ биз дээ – Сэм үг нэмэрлэв.

- За тийм байдаг байж – гэж Фродо зальтайхан инээвхийлж буй Сэм рүү харан хэлээд – харин одоо би өөрийнхөө нүд чихэнд итгэхгүй. Харахад унтаж л байдаг, чагнахад хурхирч л байдаг. Одоо би чамайг үнэн хурхирч байна уу, худлаа хурхирч байна уу гэдгийг хөлөөрөө шалгах болно!... Та нар ч бүгдээрээ лут юм аа, муусайн дээрэмчид! – гээд өөрийн эрхгүй инээд алдаж, гараа алдлаад – одоо яахав, бууж өгөхөөс, Харальдын зөвлөгөөг хүлээж авлаа. Би одоо бүжиглэсэн ч айх юм алга, гайхамшигт турсаганууд минь. Нуугаад яахав, би энэ үдшээс их айж байсан, гэтэл ийм баярт үйл явдал болдог юм байна.

- Хэлсэн бол хийсэн. Атаман Фродо болон түүний дээрэмчдэд Хуррай – гэж хашгираад хоббитууд Фродог тойрон бүжиглэж гарав.

Мерри, Пин хоёр бүжиглэхээ болиод, урьдчилан зохиосон нь мэдээж, гномууд Бильботой аян замд гарахдаа дуулсантай төстэй нэг дуу эхлэв:

Хуррай! Андууд аа, гурвуулаа дуулья!

Хагацья! Эцгийн гэр, гал голомт минь,

Хүүгэх салхи, аадар бороо,

Хүйтэн, халууныг сөрөн

Хөндийн оронд хүрээд очъё!

Эльфүүд манант уулсын дунд

Эртнээс амьдарч ирсэн оронд

Хэрцгий дайсанд үл дарагдан

Хэрэн бэдэрсээр заавал хүрье!

Хэзээ яахыг дараа шийдье!

Хөндийн орноо амраад

Хэцүү бэрх замыг туулан

Эцгийн гэртээ эргэж ирье!

Үүрийн гэгээ гийх дөхлөө!

Үүрдийн замд гарах боллоо!

- Муугүй дууллаа шүү. Хэрэв тийм бол бидэнд хийх ажил их байна, одоо энэ дээвэр дор хийж эхэлбэ, дараа нь бидэнд дээвэр байхгүй болно шүү дээ гэж Фродо хэлэв.

- Дээвэр дээврээрээ, дуу дуугаараа – гэж Пин хэлээд - чи үнэхээр үүр цайхаас өмнө хөдөлбэ гэж бодож байна уу?

- Хараахан шийдээгүй байна. Би хар морьтнуудаас айж байна, би энд буусан гэдгийг тэд мэдэж байгаа болохоор энэ байшинд удахаас айж байна. Харальд битгий сатаар гэж зөвлөсөн. Би Гэндальфтай уулзахыг маш их хүсч байна. Гэндальф ирнэ гэж амлачихаад ирээгүйд Харальд их гайхаж байсан. Хоёр асуулт байна. Нэг дэх нь: Хар морьтнууд Зайгорд хүртэл хэр удаан явах вэ? Хоёр дахь нь: Бид замд гарахад хэр удаан бэлдэх вэ? Зам... та нар мэдэж байгаа.

- Хоёр дахь асуултын хариу бэлэн, цагийн дараа ч болно. Би бүх юмаа бэлдсэн. Зургаан пони гадаа ногоо зулгааж байна, шуудайнууд пиг дүүрэн, хүйтэнд нөмрөх, ходоодонд хийх юм нэмж болох л юм гэж Мерри хэлэв.

- Туршлагатай хуйвалдагчид болохыг харж байна – гэж Фродо магтаад – гэвч Гэндальфыг нэг өдөр хүлээх үү? гэж асуув.

- Бид ч яахав хүлээнэ, харин чиний тэр хар морьтнууд хүлээх юм уу, өөрөө мэд. Тэд хүрээд ирэх нь ирсэн, Хойд хаалган дээр л саатсан байх, хамгаалалтын хэрэм тэнд гол хүртэл гурван сажин урт. Манаач шөнийн цагаар хэнийг ч яасан ч оруулдаггүй юм. Хүчээр орох гэж оролдоод үзэж болох л юм. Гэхдээ юу л бол. Тэнд өдөр ч гэсэн хүссэн бүхнийг оруулдаггүй, тэгээд сэжиг бүхий хар юмнуудыг бол бүр ч үгүй байх. Оруулсан ч, оруулаагүй ч Забренди бол цайз биш, та нар мэдэж байгаа гэж Мерри хэлэв.

Фродо хэсэг бодож байснаа:

- За ингэе. Өглөө үүр хаяармагц хөдөлбэ. Гэхдээ замаар биш. Хамгийн аюултай. Гэнэт тал талаас гараад ирвэл яана, хэдэн хар морьт байгааг би мэдэхгүй, хоёр ч юм уу, олон ч юм уу бүү мэд. Бид яг газар доогуур шургах мэт явах хэрэгтэй гэв.

- Тэгвэл та нар Мөнхийн ойгоор явах нь байна шүү дээ! Болгоомжтой! Тийшээ л биш бол хаагуур ч явсан яадаг юм, юун хар морьтнууд – гэж Бүдүүнээ дуу алдав.

- Чи энэ талаар завтай болохоороо бодож суу – гэж Мерри түүнд зөвлөөд – Тэнд мэдээж аймшигтай, гэлээ ч гэсэн Фродогийн зөв байх. Тэнд биднийг мөшгөж чадахгүй, аз болбол хэн ч биднийг хөөгөөд олохгүй гэв.

Мөнхийн ойд аз таарна гэнэ ээ? Одоо болтол хэнийг ч аз дайраагүй юм. Хөөсөн этгээд мөр алдана гэнэ! өөрсдөө та нар алга болно. Тийшээ хэн ч зүглэдэггүй юм.

- Хэн ч явдаггүй биш ээ, брендизайкууд явдаг юм. өдөр болгон явдаггүй л дээ, хэрэг гарахаар

л явдаг. Тэнд бидний жим ч бий. Фродо ч явж байсан, дээр үед л дээ мэдээж. Би ч хэдэн удаа явж байсан. өдөр, модод унтах цагаар явж байсан.

- Өөрсдөө л мэд, миний хувьд бол Мөнхийн ойгоос аймшигтай юм ертөнц дээр байхгүй, тэр тухай яриаг сонсохгүй байсан нь дээр. Би ямар та нартай явж байгаа биш. Үнэнээ хэлэхэд үлдэж байгаадаа маш баяртай байна. Гэндальф өнөө маргаашгүй хүрээд ирнэ, тэгэхээр та нарын тухай ярина.

Бүдүүн Фродод хайртай боловч Хоббитаныг орхихоос айж байлаа. Хаа нэгтээ тэнэж яваад юутай ч тохиолдоо билээ. Тэр голын цаана ч анх удаа гарч байгаа нь энэ билээ. Хуйвалдагчид ч гэсэн түүнийг авч явах гэсэнгүй, төлөвлөгөө ёсоор тэр байшинг манаж, сониуч этгээдүүдийг төөрөлдүүлэн ноён Торбинс энд байгаа, саяхан гадагшаа гарсан гэж хэлэх ёстой байв. Торбинсынхны хуучин хувцаснаас ч авчирсан, Бүдүүнээ өмсөх ёстой. Энэ бол хамгийн аюултай дүр гэдгийг хэн ч бодсонгүй.

Хуйвалдагчдын энэ төлөвлөгөөг Фродо бодож үзээд:

- Сайн байна! Гэндальфт бид өөрөөр яаж мэдээ хүргэх билээ, энэ хар морьгнууд бичиг унших нь юу л бол, гэлээ ч гэсэн би захиа орхиж азаа туршихгүй. Харин Бүдүүнээ энд байвал бодох ч юм алга. Гэндальф биднийг гүйцэж л таарна. Тэгэхээр үүрээр Мөнхийн ой руу!

- Надад нэг асуулт байна – гэж Пин хэлээд – ой руу орвол ч орьё. Гэхдээ би Бүдүүнээд атаархахгүй байна. Хар морьгнуудыг ч харах шиг болно доо!

- Би ч чамд атаархахгүй, Мөнхийн ой руу орчихсон хойноо буцах гэтэл оройтсон байх вий

- За за, маргахаа больё, дахиад бага сага юм боож баглах хэрэгтэй байна. Би та нарыг үүрийн харанхуйгаар сэрээнэ гэж Мерри хэлэв.

Фродо хэвтсэн боловч нойр нь хүрсэнгүй. Хөл янгинаж байна, яамай даа маргааш мориор явна. Тэр бага багаар зүүрмэглэсээр бүдэг бадаг зүүдэлж эхлэв. Тэр цонхоор харанхуй ой руу харж байна, моддын доогуур ямар нэг хачин муухай юмнууд газар үнэрлэн мөлхөж байна, тэд заавал наашаа ирэх нь.

Алсаас шуугих чимээ гарлаа. Салхи навчсын дээгүүр гүйв бололтой. Үгүй ээ, салхи биш байна, алсын тэнгисийн давалгаа байна. Тэнгисийн давалгааг тэр хэзээ ч сонсч байгаагүй, зөвхөн зүүдэндээ л сонссон билээ. Дараа нь цонх алга болж, удам тал нэлийв. Нэг ч модгүй, эргэн тойронд өвс сэрчигнэж, шорвог үнэр хамар цоргино. Тэр дээш хартал эгц хадан хясаан дээр өндөр цагаан цамхаг үзэгдэв. Түүн дээр гарч тэнгис хармаар санагдаад хясаа өөд авирч байтал гэнэт хурц цахилгаан тэнгэрийг гэрэлтүүлж, аянга нижигнэв.

Бүлэг 6

Мөнхийн ой

Фродо босон харайв. Өрөөнд харанхуй. Мерри хонгилд лаа барин зогсоод хагас нээлттэй хаалгыг чанга гэгч балбаж байв.

- Чимээгүй! Юу болоов? – гэж Фродо нойрмог дуугаар асуувал:

- Бас асууж байна уу? – гэж Мерри гайхаад – босоцгоогооч, дөрөв хагас болчихсон. Хашаан дотор юу ч харагдахгүй манан буучихаж. Босоорой, Босоорой! Сэм өглөөний хоол хийж байна. Пин босчихсон. Би гарч морьдоо эмээллээ. Бүдүүнээг сэрээ! Ядаж биднийг үдэг.

Долоон цаг болоход бүгд замдаа гарахад бэлэн болов. Бүдүүнээ ам мэдэн эвшээнэ. Тэд байшингаас чимээгүй гарч арын жимээр хүнд ачаатай пони морьд хөтөлсөн Меррийн араас цувран эхлээд төглөөр, дараа нь нугаар явлаа. Модны навчис шүүдрийн усыг дааж ядан, навч бүрээс ус дусалж, хүйтэн шүүдэр өвс ногоог саарал усан бүтээлгээр хучжээ. Нам гүм, алсын чимээ хажууд юм шиг тодхон, тахианууд нуг нуг дуугарч, хаа нэгтээ хаалга тасхийтэл хаагдаж, хашааны хаалга чихарч байна.

Эмээлтэй пони морьд өвсний хашаанд байв. Хоббитуудад яг таарсан жижигхэн, удаавтар боловч тэсвэр сайтай адуу билээ. Оргодлууд морьдоо унаад өтгөн манан руу орлоо. Манан тэдний өмнө дуртай дургүй нээгдэж, оронгуут нь араас нь хааж авах мэт. Цаг орчим алхуулсны дараа урд нь асар өндөр, мөнгөлөг өнгөт аалзны тороор бүрэгдсэн Хэрэм тулав.

- Бид давах юм уу? – гэж Фродо асуухад Мерри:

- Миний хойноос! Юу болохыг үзнэ гайгүй гээд зүүн тийш эргэж, Хэрмийн дагуу явтал хэрэм жалга руу тулаад хойш эргэжээ. Жалга руу нэлээд гүн хэвгий замаар бууж тоосгон ханатай газар доогуурх гарцанд тулав. Гарц хашаан доогуур гараад цаад талд нь жалга руу оржээ. Бүдүүн Минж жолоогоо татаж:

- Баяртай Фродо! Ой руу дэмий л явсан юм даа, өнөөдөр л гай газар дороос гараад ирвэл яана. Гэлээ ч гэсэн та нартаа аз ерөөе, өнөөдөр, маргааш, өдөр бүр аз хийморьтой явах болтугай! Гэхэд нь Фродо:

- Хэрэв миний өмнө зөвхөн Мөнхийн ой байгаа бол би аз жаргалтай байхсан, Баруун зам руу яар гэж Гэндалффт хэлээрэй, бид ойгоос гараад тийш явна, тэнд уулзана биз дээ. Баяртай! - гээд хонгил руу орж Бүдүүнээ дээр ганцаар үлдэв.

Хонгил харанхуй, чийгтэй бөгөөд төмөр хаалганд тулжээ. Мерри хаалгыг яаран нээж, бүгдээрээ гарсны дараа тасхийтэл хаахад түгжээ нь тавхийн түгжигдэв.

- За ингээд буцах зам хаагдлаа. Баяртай Хоббитан минь, бидний өмнө мөнхийн ой байна гэж Мерри хэлэв.

- Ойн тухай үнэн ярьцгааж байгаа юм уу? гэж Пин асуухад:

- Юу гэж ярьснаас л болно. Хэрэв чи Бүдүүнээг багад нь айлгадаг байсан намгийн савдаг, чоно гэх мэтийн элдэв аймшгийн амьтдын тухай яриаг хэлж байгаа бол юу л бол. Би тэр үлгэрүүдэд итгэдэггүй. Гэхдээ энэ ой гайхалтай шүү. Бүх юм нэг л зэвүүн, Хоббитантай адилгүй. Моднууд нь харийнханд их дургүй, араас нь хараад л байна-хараад л байна- хараад л байна... нүд байхгүй юм чинь навчаараа хардаг юм уу яадаг юм. Өдөр бол ч яахав, харж л байна биз, тийм аймаар биш. Заримдаа нэг мод дээрээс чинь мөчир унагана, нөгөө мод үндсээрээ дэгээднэ, гурав дахь нь мөчрөөрөө ороолгоно. Тиймэрхүү юм байдаг л юм. Энэ ч яахав, байдаг л зүйл. Харин шөнө... янз янзын л юм ярьцгаадаг юм. Би өөрөө нэг хоёр шөнө энд байсан, тэхдээ ойн цоорхойд хоносон юм. Моднууд хоорондоо шивнэлдээд, ямар нэг муу юм хийх тухайгаа үл ойлгогдох хэлээр хэлэлцээд л байх шиг санагдсан, салхигүй байхад мөчрүүд нь найгаж, сэрчигнээд л, моднууд нь явдаг, харийнхныг хэрэм шиг бүслээд авдаг гэгцгээдэг юм. Тэр ч байтугай нэгэн цагт манай Хэрэм рүү тулж ирээд шахаж, эвдэлж, дээрээс нь дарж байсан гэлцдэг юм. Тэгэхэд нь хоббитууд Хэрэмнээсээ гарч хэдэн зуун модыг тайрч унагаад их гал түлж, Хэрмийн дагуу өргөн зурвасыг шатаасан гэдэг. Ой ухарсан боловч өс хонзон санасан хэвээр. Шатаасан зурвас нь одоо ч байдаг юм, тэнд Ой руу жаахан гүн орохоор харагдана.

- Модноос өөр айх юм байхгүй юу?

- Байдаг гэсэн, ойн янз бүрийн мангасууд. Гэхдээ энд биш, Бургастын хөндийд. Жимийг ч гэсэн хэн нэг нь гаргадаг. Хаашаа л харна жим, хаашаа ч явдаг юм чөтгөр бүү мэд, тэгэхдээ ирэх болгонд өөр жим байна. Энүүхэнд Түймрийн Цоорхой руу хөтөлсөн том жим байсан юм, одоо байна уу, үгүй юу, тэрний цаана ойролцоогоор зөв чигт, зүүн хойш чиглэсэн жижиг жим хөндлөн гардаг юм. Ер нь хайгаад үзье.

Төгсгөлгүй мэт жалгаас дээш Ой руу дөнгөж мэдэгдэхүйц нарийхан зөрөг гарч ирээд тэр дороо алга болжээ. Ойд ойртож ирээд тэд эргэж харав. Ард Ханан Хэрэм бүдэгхэн зурвас адил харлан харагдаж, хариугүй далд орж байна. Өмнө зөвхөн шулуун, муруй тахир, арзгар холтостой, гөлгөр холтостой, боргоцойтой, мөчирлөг, ногоон саарал, бутаар хучигдсан янз бүрийн моднууд л байна. Ганц Мерри л сэтгэлээр унаагүй явна.

- Чи тэр замаа хай хай! Тэгэхгүй бол нэг нэгээрээ салж одно, эсвэл бөөнөөрөө төөрнө - гэж Фродо баргар царайлан Мерриг шавдуулав.

Пони морьд моднуудын хоорондуур сурамгай сүлжиж, хоорондоо хэлхэлдсэн муруй тахир үндэснүүдийн дундуур болгоомжтой алхлан явна. Залуу ой, залуу мод нэгээхэн ч үгүй. Налуу бэлээр уул өөд өгсөх тусам модод улам өндөр, улам харанхуй, улам өтгөн болсоор. Нам гүм дүлий оргин, хааяа нэг хүндэрсэн дусал хөдөлгөөнгүй навчин дээрээс доош унана. Мөчрүүд амьгүй мэт нам жим, сэрчигнэх чимээ хаанаас ч үл сонсдох бөгөөд модод тэднийг үзээд хүйтэн, сэжиглэнгүй, дайсагнасан байдалтай ажиглаж байгааг хоббитууд мэдэрч байлаа. Хоббитууд гэнэтийн довтолгооноос сэрэмжилж, байн байн хурдан хурдан эргэн харж, тал тал тийш ажиглаж явлаа.

Жим олдсонгүй, моднууд зам хааж, Пин гэнэт цаашаа явж чадахгүйгээ мэдрэх шиг болов.

- Хөө-өөе, хүү-үүе! Би ямар ч муу санаа агуулаагүй, намайг явуулаач! – гэж гэж тэр байдаг хоолойгоороо хашгирав.

Айсандаа бүгд нам зогссон боловч Пиний дуу ойгоор нэг цуурайтсангүй, амыг нь барьсан юм шиг аг чиг болов. Цуурай ч байдаггүй, хариу чимээ ч байдаггүй: зөвхөн ой улам өтгөрч нягтран, бах нь ханаж байгаа юм шиг сэрчигнэв.

- Би л чи байсан бол хашгирахгүй, сохор зоосны ч ашиггүй, харин ч хор болж мэднэ – гэж Мерри хэллээ.

Фродо цааш явах зам аль хэдийн байхгүй болсон, нөхдөө дэмий л энэ хорт ой руу орууллаа даа гэж бодов. Мерри зам хайсаар байсан ч нэг л итгэл муутай байгааг Пин ажиглалаа.

- Чи бүр хөдлөнгүүтээ төөрчихлөө - гэж түүнийг хэлэхэд Мерри санаа амарсан байртай исгэрээд урагш заалаа.

- Юм ч болох нь дээ, энэ моднууд байран дээрээ зогсч байдаггүй юм байна, явдаг нь үнэн байх нь. Түймрийн цоорхой, тийшээ явдаг зам хаачдаг байна аа – гэж Мерри бодлогошрон байж хэлэв.

Тэдний зам гэрэлтэй болж, моднууд ухрав. Тэд гэнэт мөчрүүдийн дороос шурган гарч, уудам талбайд гарч ирлээ. Дээр нь санамсаргүй цэлмэг цэнхэр тэнгэр харагдав. Наран хараахан өндөрт мандаагүй боловч найрсаг туяа нь тусч байна. Түймрийн цоорхойн захын навчис тэр талбайг Ойгоос хааж байгаа юм шиг өтгөн бөгөөд ногоон байв. Цоорхойд нэг ч мод байхгүй, ширүүн өвс, царай муутай сийрэг бутнууд байна. Энд ургамал бүхэн гандаж гундсан боловч Мөнхийн ойн захаас гарч ирсний дараа энд жигтэйхэн сайхан байлаа.

Хоббитуудын урам сэргэв. Наран мандаж, дээр нь тэнгэр гийж, өдрийн гэрэл мэлсхийтэл тусав. Цоорхойн цаад талд, моддын дундуур гэнэт тодхон жим дурайж харагдав. Тэр жим налуугаар дээшлэн ой руу орж, дээгүүр нь өтгөн мөчрүүд унжин, нэг нийлж, нэг салж харагдана.

Тэд одоо хөгжилтэй, Ой биднийг өршөөлөө, ямар ч гэсэн нэвтрүүлнэ гэж найдан, өмнөхөөс хавьгүй хурдан явж байв. Гэвч тэдний санаснаар болсонгүй: удалгүй нууц шид ил болов. Бүгчим агаар дотор давчдуулж, моднууд тэднийг хоёр талаас нь хавчин, замыг нь хаав. Морьдын туурай илжирсэн навчист шигдэж, далд үндсэн дээр тогшин, дүлий нам гүмд туурайн энэ чимээ чихэнд чийртэй байлаа. Фродо нөхдийнхөө сэтгэлийг сэргээхийн тулд чангаар дуулах гэсэн боловч хоолой нь гарч өгсөнгүй, дөнгөж дуулдах төдий байв.

Хар сүүдэр дундуур зоригтой урагшил

Харанхуй манан мөнх бөөгнөрөхгүй

Хар ойг туулахдаа л нэг туулна.

Наран мандаж тэнгэрийг гийгүүлнэ:

Үдшийн бүгээнээр, өглөөн гэгээнээр

Үүрийн туяа салхи татуулан

Үнэгэн харанхуйг тарааж хөөнө,

Үүрд тонилгоно...

Цааш дуулах гэтэл хоолой бачуурч, үг ч амнаас нь гарахгүй болов.

Жим дээгүүр нэлмийтэл нөмөрсөн модноос нэг асар том арзгар мөчир ар нуруунд нь тасхийн буув. Өмнөх моднууд улам нягтран бөөгнөрлөө.

- Тэднийг туулахдаа л нэг туулна гэхээр уурлаж байх шиг байна. Одоохондоо дуугаа дуулаад жаахан хүлээе. Цоорхойд гараад эргэж ямар нэг дуу хоолой нийлүүлж чанга дуулья! – гэж Мерри хэлэв.

Тэр хоолойнхоо чичрээг дарахыг хичээж, шоглонгуй аясаар хэлсэн боловч хэн ч хариу хэлсэнгүй: бүгд л айсан байлаа. Фродо хөнгөмсөг загнасанддаа өөрийгөө зүхэж, нөхдөө бүгдийг нь буцаая /өөрөөр хэлбэл хааш нь ч бүү мэд/ гэж бодтол гэнэт моднууд хоёр тийш ярагдан аянчдыг тэгшхэн талбайд гаргаж, жим хоёр шанааны үс нь боссон халзан зулай шиг модгүй ногоон толгой өөд шулуухан зурайж харагдав.

Тэд Мөнхийн ойн дарлалаас түр зуур ч болов гарахын тулд дахиад л урагш тэмүүлэв. Жим тэднийг газрын уруу хөтөлж, дахиад уул өөд өгсүүлээд эцэст нь эгц, задгай өндөрлөгт хүргээд өвсөн доогуур шургаж алга болов. Толгойн эргэн тойронд ой халзайн зулайг тойрсон өтгөн үс шиг хүрээлжээ.

Хоббитууд толгойн орой дээр гараад эргэн тойрноо харав. Нарны цэнхэр будан алсын харааг хязгаарлаж байлаа. Ойр орчинд манан бараг сарнисан боловч алсад ойн завсраар доош сууж, өмнө зүгт Ойг хөндлөн гарсан гүн жалгаас уур мэт хөөрөн тал тал тийш мөлхөж байв.

- Тээр тэнд өмнөд нурууны толгодоос Бургаст гол эх авч, баруун өмнө зүг рүү Ойн гүн рүү ороод Ойг хөндлөн гарч Брендидиум мөрөнд цутгадаг юм. Бид тийшээ л явсны хэрэггүй байх. Тэр голоос л ойн гол ид шид эхэлдэг гэж ярьцгаадаг юм- гэж Мерри хэлэв.

Гэвч Мерригийн заасан тэр зүгт голын гүн чийглэг хөвөөн дээгүүрх манан Ойн өмнөд хагасыг бүхэлд нь хааж байлаа. Арваннэгэн цаг орчим болж, нар шарсаар байсан боловч намрын будан манан нэвтрэх аргагүй хэвээр байв. Дөрвөн талаас нь нүд гүйцэх аргагүй уудам Ой ногоон давалгаагаараа тэднийг хүрээлсэн учир баруун тийш хичнээн хараад ч Ханан Хэрэм болон Голын хөндий харагдахгүй, хойшоо хараад Их Баруун Зам ч харагдахгүй байлаа.

Хоббитууд ногоон толгой дээр суугаад хязгааргүй их ойг харангаа хооллож ундлав. Үд болоход тэртээ дорно зүгт Мөнхийн ойн цаадах Булшийн Толгодын сааралдуу дүрс тодров. Тэр дүрс аянчдыг их баярлууллаа: ямар ч гэсэн энэ ойд зах хязгаар байдаг юм байна. Гэвч тэд тийшээ явахыг хүссэнгүй, Булшийн Толгодын тухай хоббитын домгууд Ойн тухай ярианаас

илүү аймшигтай байсан юм.

Үдийн хоолоо идэж, сэтгэл санаагаа сэргээж аваад тэд доош буув. Алга болсон зам заагч жим ногоон толгойн хойд бэлээс олдож, умар зүг хөтлөв. Гэвч жим аажмаар баруун тийшилж, зүүн өмнө зүг рүү явж байгааг тэд баярлаж амжихаасаа өмнө ойлголоо. Удалгүй жим налуу руу бууж эхэлсэн нь Бургаст гол руу, өөрөөр хэлбэл огт хэрэггүй зүг рүү хөтөлж байгаа нь тодорхой болов. Хоббитууд зөвлөлдөөд хуурамч жимийг орхиж, зүүн тийшээ, төгөл рүү эргэн хойт зүг таамгаар явахаар шийдэв. Тэд толгой дээрээс Их баруун замыг хараагүй боловч одоо яая гэх билээ. Харин энд ер бусын хачин соднууд биш ердийн гацуур, нарс модод ургасан байлаа.

Эхлээд тэд зөв явж байгаа юм шиг байв. Хэдийгээр нар навчсын хоорондуур нэвтрэхдээ бараг л ар нуруунаас төөнөж байсан боловч тэд хурдан явж байлаа. Дахиад л модод ойртож эхэллээ. Хаанаас ч гараад ирснийг бүү мэд гүнзгий ганга зам хааж, өргөст ургамлаар битүү хучигдсан жалга, хонхрууд тулж байсан ч аянчид тэгэхээс тэгэх гэсэн юм шиг дайраад л гарч байв. Тэдгээрийг тойрох боломжгүй, доогуураа шигүү ширэнгэн бут, зүүн талаараа оролдох ч хэрэггүй, баруун талаараа яаж ийгээд нэвтэрч болмоор. Баруун талыг барьж арайхийн дээш гарч иртэл моднууд харанхуй хана болон нягтарч зүүн тийш уул өөд явуулахгүй байсан тул арга буюу баруун тийш уул руу уруудав.

Цаг орчмын дараа тэд зүг чигээ алдаж, зөвхөн хойшоо л явж байгаа гэж мэдэж байв. Хэн нэгэн тэднийг хөтөлж, тэд дуулгавартайгаар улам л зүүн өмнө зүг рүү Ойн яг гүн рүү дөтөлж байлаа.

Аянчдыг бусдаас илүү гүнзгий бөгөөд өргөн жалга руу орж ирэхэд нар баруун зүг тонгойж байлаа. Жалга руу тэд бараг л өнхөрч буусан бөгөөд тийм эгц эрэг өөд урагшаа юм уу буцаад гарах тухай бодох ч хэрэггүй байв. Морьдоо ачаатайгаа хаяад явалтай биш. Зүүн тийш мэдээж явах боломжгүй учир баруун тийш жалгаар уруудав. Хөл дор намгархаг хөрс шал шал хийж, энд тэндгүй булаг урсч байсан бөгөөд удалгүй тэд намаг дундуур нэвтрэн гарч ирсэн шоржигнуур, шулганаа горхи даган явж байгаагаа ойлгов. Дараа нь налуу улам эгц болж, горхины ус голдрилоосоо хальж, итгэлтэйгээ хүржигнэн эрэг рүү бууж байлаа. Аянчид дээрээсээ моддоор сүүдэрлэгдсэн бүрэнхий судгаар явж байв.

Гэнэт тэдний өмнө хаалга нээгдэх шиг болж, нарны туяа мэлсхийв. Тэд эгц өндөр шавар эргийг тасалсан асар том хонхроос гарч ирлээ. Хөлд нь өтгөн ургасан зэгс орооцолдож, өмнө нь бас нэг эгц, халтиргаатай эрэг сүндэрлэнэ. Жижигхэн голын хөндийд бүгчим халуун нозооруулна. Дундуур нь хоёр талаараа бургаас, бутаар битүү хашигдсан, үжирмэл нарс, наалданги хус урсгалд нь тээглэсэн булингарт гол үй мянган унамал навчис хөвүүлэн урсана. Халуун салхи үлээж, зэгс шаржигнаж, бургаас, нарсны мөчрүүд шивнэлдэнэ.

- Биднийг хааш авчирсан нь одоо л ойлгомжтой боллоо. Бүр хамгийн буруу тал руу. Энэ бол Бургаст гол! Би яваад жаахан тагнуулдаад ирье – гэж Мерри хэлэв.

Тэр нар туссан талбай дундуур гүйгээд өвсөн дунд далд оров. Тэгснээ газраас ургах мэт гэнэт гарч ирээд – Яг эргийн тэнд намгараг биш хөрстэй, ёстой сайхан жим байна гэж зарлав.

- Түүгээр зүүн тийш явья, нэг харахад л зүүн талын ойн цоорхойд гарч ирнэ.

- Ээ мэдэхгүй – гэж Пин толгой сэгсрээд - Хэрэв жим биднийг намагт хийчихгүй шиг хөтлөөд явбал бид гараад л ирэх байх. Хэн, яах гэж жим гаргасан гэж чи бодож байна? Бидний төлөө гаргагүй байх аа. Энэ ойд орж ирснээс хойш надад нэг л хачин санагдаад байна, одоо би энэ газрын тухай ямар ч үлгэрт итгэхэд бэлэн байна. Зүүн ойн цоорхой хүртэл хэр хол гэж бодож байна?

- Ёстой мэдэх юм алга. Бид одоо Бургастын доод биенээс хол байна уу, үгүй юу, хэн энд жим гаргасан бэ гэдэгтэй л адилхан. Нэг л юм мэдэж байна. Энэ ч мөн сайхан хуушуур даа.

Өөр зам байхгүй тул тэд Мерригийн араас цувран түүний олсон үл мэдэх жим рүү явлаа. Өндөр, өтгөн ургасан зэгсэнд хоббитуудын толгой далд орж байсан ч нэг олдсон жим хаашаа ч алга болсонгүй, намаг, хонхор хотгор дундуур сүлжин сүвэгчилж байлаа. Замын туршид ойн дээд хэсгээс Бургаст руу тэмүүлсэн горхинууд тааралдах бөгөөд дээгүүр нь бүдүүн мод юм уу эсвэл боосон мөчрүүд хэрэг болгож тавьсан байв.

Бүгчим халуун хоббитуудыг туйлдуулж байлаа. Толгой дээгүүр нь шумуулан үүл тасралтгүй шунгинаан, нар ар нурууг нь хайр найргүй төөнөж байв. Эцэст нь жимийг ганц нэгхэн навчтай хатангир мөчрүүдийн сийрэг саарал сүүдэр бүрхэв. Явах тусам улам бүгчим, хүнд болсоор. Газар нойрмог нозоорол ялгаруулан байх мэт, ууршсан агаар нозоорлоор дүүрэн.

Фродо хүндээр үүрэглэн тонголзож явав. Түүний урд хөлөө арай ядан зөөж яваа Пин гэнэт өвдөг сөхрөв. Фродо морио зогсоож, Мерри:

- Дэмий биеэ зовоогоод яах вэ, би дахиад нэг ч алхахгүй. Унтах хэрэгтэй байна. Тэр нарснуудын дор арай сэрүүхэн, ялаа шумуул ч бага байна –гэв.

Түүний итгэл муутай дуу хоолой Фродод таалагдсангүй. Тэгээд :

- Сэргээрэй! Унтдаг цаг биш. Эхлээд ойгоос гарах хэрэгтэй – гэж хашгирлаа.

Гэвч дагуулуудыг нь нойр хүлжээ. Сэм эвшээж, нүдээ цавчилна. Фродо өөрөө ч унтаж байгаага мэдрэв. Нүдний өмнө бүх юм хөвж, ой гутам ялаа шумуулын шунгинаан гэнэт тасрав. Зөвхөн хөнгөн шивнээ, зөөлөн шоржигноон, алсын сэрчигнээн л байлаа. Навчнууд юм болов уу? Мэдээж навчнууд.

Тэр ядарсан нүдээ нээж, дээр нь аварга том эртний үжирмэл нарс бөхийж байгааг харав. Тэр мод үй олон гараа дэлгэх мэт урт, тахир, саарал мөчрүүдээ дэлгэжээ. Түүний асар бүдүүн хатмал холтос хар ангархайнуудаар дүүрэн бөгөөд нойрмог навчны сэржигнээн дор үл мэдэг чихарна... Фродо амаа байдгаар нь ангайн эвшээгээд өвсөн дээр унаад өгөв.

Мерри, Пин хоёр арай ядан аварга том модонд хүрээд ангайсан хар ангархайнуудыг нь нуруугаараа налан суув. Сэм араас нь салгалж айсуу.

Дээгүүр нь шаравтар саарал навчнууд хөшиглөн ганхана. Аянчид зовлонтойгоор нүдээ аньж,

зүүрмэглэх зуураа: Нарсан дор ус, ус хүлнэ, ус татна, ус унтуулна – гэж сонсох шиг... тэд аварга саарал нарсны дор голын чимээгээр бүүвэйлүүлэн унтаад өглөө.

Фродо бүх хүчээ дайчлан нойрыг хөөгөөд хөл дээрээ босч чадав. Тэр бүх хүчээрээ ус руу тэмүүлнэ.

- Сэм, хүлээж байгаарай, хөлөө... усанд дүрвэл сайн сан... гэж тэр бувгнав.

Хагас унтаагаар, модны их биеэс барьж байгаад тахир бүдүүн үндэснүүд нууран дахь лууны зулзага адилаар шургаж орсон усанд хүрэв. Тэгээд нэг үндсэн дээр зайдлан сэрүүхэн хүрэн усанд хөлөө булхаад аварга том модыг налан тэр дороо унтлаа.

Сэм суугаагаараа, ам мэдэн эвшээж, шилэн хүзүүгээ маажив. Хачин юм. Нар жаргаагүй байдаг, эд нар унтаад л байдаг, унтаад л байдаг. Яагаад?

“Ядраа юм биз дээ, яршиг л байна. Энэ мод хэтэрхий том юм, бас айхтар сэржигнэдэг эд байх нь хөөе, энэ ус өөр рүүгээ татаад, нойр хүргээд байх юм. Унтаад сайн юм болохгүй” гэж бодов.

Тэрбээр нойрыг үлдэн хөөгөөд босч морьдоо харахаар явлаа. Хоёр морь жимээс холхон идээшилж байхыг хараад авчирч явгал ус хүчтэй цүл палхийж, аяархан торжигнох чимээ сонсдов. Бас ямар нэг юм ус руу унаж, хаа нэгтээ хаалга тасхийтэл хаах шиг болов.

Сэм эрэг рүү ухасхийн очвол эзэн нь яг эргийн дэргэд толгойгоороо ус руу шаан унаж, бат бэх, урт үндэс түүнийг сэмхэн живүүлж байх бөгөөд Фродо эсэргүүцэх ч үгүй байв.

Сэм эзнийхээ хүрэмний захаас шүүрэн авч, үндэсний дороос татан гаргаад дараа нь эрэг дээр арайхийн гаргаж ирэв. Фродо ухаан орж, хахаж цацан, ам хамраас нь ус садхийн асгарч байлаа.

- Сэм, мод намайг ус руу хийчихлээ ш дээ, үндсээрээ тэвэрч аваад л шидчихсэн гээд бодчих гэж тэр хэлэв.

- Юу гэхэв дээ эзэн минь, унтчихсан байна. Тэгж их нойр чинь хүрсэн юм бол ядаж уснаас холдохгүй.

- Манайхан хаана байна? Бас унтчих вий дээ!

Сэм, Фродо хоёр модыг тойрч харав. Пин алга. Түүний налж суусан ангал огт байхгүй байсан юм шиг оргүй алга болжээ. Меррийн хөл өөр нэг ангалаас цухуйж байв.

Манай хоёр эхлээд Пиний сууж байсан газарт модыг гараараа балбав. Дараа нь ангальг ангайлгаж Мерриг гаргах гэж оролдсон боловч бүтсэнгүй.

- Би мэдээд байсан юм аа! Биднийг энэ хараал идсэн ой руу юу хөөгөөд ирсэн юм бэ? Судагтаа л сууж байдаг байж – гэж Фродо хэлээд модыг байдаг хүчээрээ өшиглөв. Модны гол болон мөчрүүд үл мэдэг чичирхийлж, навчнууд нь сэржигнэн шоолж байгаа бололтой

ШИВНЭЛДЭВ.

- Эзэнтээн! Та сүх аваагүй биз?

- Мөчир цавчих сүх байгаа л даа. Гэхдээ тийм сүх хэрэг болох юм уу?

- Байз байз, гал түлбэл ямар вэ? Тус болох юм биш байгаа?

- Бололгүй яахав, Пинийг л шарна биз, өөр яав гэж.

- Ямар ч гэсэн энэний арьсыг нь хуйхлаад өгье, айж л таарна. Хэрэв тэр хоёрыг гаргаж өгөхгүй бол би тэртэй тэргүй энэнийг заавал унагана, шүдээрээ мэрээд ч хамаагүй – гэж Сэм заналтайяа өгүүлээд морьд руугаа очиж сүх, хэт цахиур авчрав.

Тэгээд нөгөө хоёрынхоо сууж байсан талын эсрэг талд хуурай мөчир, зомгол авчирч овоолоод гал асаав. Гал тэр дорхноо дүрэлзэн аварга модны арзгар хальс руу шигдэх мэт болоход эртний аварга мод татавхийж, навчнууд нь ёлолдов. Мерри чанга хашгирч, Пиний бөглүү дуу сонсогдлоо.

- Унтраагаарай! Унтраагаарай!- Тэгэхгүй бол намайг хоёр тасалж залгина гээд байна – гэж Мерри өөрийн биш дуугаар хашгирав.

- Хэн тэгж байна? Чи яаж байна? – гэж Фродо асуугаад ангал руу ухасхийв.

- Унтраагаарай! Хурдан унтраагаарай!- гэж Мерри орилно. Нарсны мөчир хилэнтэйеэ ярсхийж, ойр хавийн бүх мод түгшүүр зарлах мэт, голын усанд том том чулуу унах мэт болов. Ой нэлэнхүйдээ хилэгнэж байх шиг. Сэм галаа яаран унтрааж, очсыг нь дэвслэв. Фродо өөрийн ухаангүй жимээр хаа нэг тийш гүйж “туслаарай! туслаарай! Тусл-аа-аа-рай!” хэмээн хашгирна. Байдаг хоолойгоор бархирч байсан боловч өөрийнхөө дууг бараг сонсохгүй байв. Модны босгосон хуй салхи, навчсын галзуу мэт сэрчигнээн дууг нь дарж байлаа. Гэсэн ч Фродо айж сандарсандаа улам л хашгирсаар байв.

Тэгснээ гэнэт чимээгүй болов. Хэн нэгэн хариу хэлэх шиг болов. Тэгж санагдсан юм болов уу? Үгүй юм аа, ар талаас, ойн гүнээс хариу хашгирч байна. Тэр эргэж хараад чагнатал хэн нэгэн баяр хөөртэйгээр, огт ойлгомжгүй дуу дуулж байв:

Гол –жалга, нойтон жалга, жалгын дээр уулс

Хуурай хөвд, юунаас болов, чийглэг жалга, тал хөндий...

Фродо, Сэм хоёр тус болж магадгүй гэж найдсандаа, шинэ аюулаас айсандаа таг чимээгүй зогсов. Гэнэт утга учиргүй үгс утгатай болж, дуу улам ойртов:

Илжирч өмхөрсөн эртний ой, мөнхийн ой

Исгэрч үлээсэн салхи, жигүүртний дэвэлт,

Алтан нар жаргалаа, үдэш боллоо.

Алтангаа охин цонхны дэргэд Томыг хүлээж байгаа.

Мөрөн голын охин, гэгээн хатан хаан Алтангаа

Мөддөө ирэхгүй Томыгоо өдий болтол хүлээж байгаа.

Эхнэртээ усан лянхуа түүгээд дуугаа аяллаа.

Эртний ой, мөнхийн ой

Эгшиг дууг нь түрлээ:

Зуны өдөр цэнхэр, хаврын үдэш хар,

Хаврын аадар илбэч, зуных шүлэгч.

Нарс, царс модод минь зам тавь,

Надад та нартай хэрэлдэх зав алга.

Навчис, зэгс минь гунигтай бүү исгэр

Наалинхай Алтангаадаа Том яарч явна.

Тэр хоёр илбэдүүлсэн мэт нам зогсов. Салхи амьсгалаа хураасан мэт нам гүм болж, навчис номхорсон мөчрөөсөө хөдөлгөөнгүй дүүжлэгдэв. Мөнөөх дуу дахин цуурайтсанаа зэгсэн дотроос гэнэт туузаар ороосон урт цэнхэр өд бүхий үнгэлдсэн бүрх малгай гараад ирэв. Малгай дор үлэмж биетээс арай намхан мөртөө гурав дахин хурдан алхдаг хүн байлаа. Бүдүүн хөлдөө өмссөн шар гутал нь өвсийг бухын туруу мэт хаман алхана. Хөх цамцных нь дээд хэсгийг их сахал нь хаах бөгөөд нүүр нь инээдийн үрчлээгээр дүүрэн, болсон алим шиг улаан ажээ. Гартаа том тавиур барьсан байх ба тавиур дээр нь усан лянхуа цэцэгнүүд байна.

- Туслаарай – гэж хашгиран Фродо, Сэм хоёр урдаас нь гүйв.

- Чимээгүй! Юундаа орилоод байгаа юм бэ! – гэж танихгүй эр хэлээд гараа урагш сунгахад мань хоёр шаасан гадас мэт зогсов.

- Хаашаа гүйгээд байгаа юм бэ? Хурдан хариул! Би эндхийн эзэн Том Бомбадил байна. Ийм хачин тогжгор амьтдыг хэн гомдоодог байна?

- Найз нарыг маань сорчихсон. Нарс! – гэж Фродо арайхийн амьсгаагаа дарж хашгирав.

- Ойлгож байна уу эзэнтэн минь, тэднийг унтаж байхад нь мод сорж авчихаад тавихгүй байна- гэж Сэм тайлбарлав.

- Хөгшин нарс зүггүйтэж байна уу? Ердөө л энэхэн үү? – гэж Том Бомбадил хашгираад хөгжилтэйхэн цовхорч - Би одоо тэрэнд дуулж өгье – нам унтуулаад өгье. Навчсыг нь мөчрөөсөө салтал дуулаад өгье! Тэсгим хүйтнээр дуулж, үндсийг нь хөлдөөгөөд өгье!

Тэр цэцэгтэй тавиураа өвсөн дээр болгоомжтой тавиад Меррийн хөл цухуйж байгаа мод руу харайж очоод ангалд нь уруулаа хүргэн үл ойлгогдох ямар нэг дуу аяархан дуулав. Мерри баяртайгаар хөлөө сарвагануулсан боловч мод яасан ч үгүй. Том ухасхийн доод талын хүнд мөчрийг хугалаад модыг шавхуурдав.

- Хөөе хөгшин нарс аа! Чи Том Бомбадилыг сонс!- гэж тэр тушаал буулгаад –Газрын шүүсийг ханатлаа ууж хүч тамираа сэлбэ, тэгээд унт. Чи бүр шарлачихсан байна шүү дээ. Наад багачуудаа тавь! Амьтанг барьж иддэг болох нь! – гэлээ.

Модны ангал ангайхад тэр Меррийн хөлөөс шүүрэн түүнийг суга татаж гаргав.

Дараа нь өөр нэг ангал хүндээр чихран нээгдэхэд Пин бөгс рүүгээ өшиглүүлсэн мэт үсрэн гарч ирэв. Хоёр ангал ууртай хөгшин дуугаар харжигнан хаагдаж, модны их бие чичирхийлснээ нам гүм болов.

- Танд баярлалаа – гэж дөрвөн хоббит зэрэг хэлэв.

Том тачигнатал инээгээд:

- За зүгээр сууж чаддаггүй туулайнууд минь, манайд очиж амарцгаа, та нарыг сайхан дайлна аа. Бүх асуултаа дараа бол. Нар шингэлээ, Алтангаа хүлээж байгаа- биднийг тэсэн ядан хүлээж байх шиг байна. Ширээн дээр талх, бал, сүү, өрөм... За багачууд минь гүйгээд марш! Том өлсч байна!

Тэр цэцэгнүүдээ авч, миний хойноос гэж гараараа дохиод ямар ч утгагүй мэт нэг дуу аялан зүүн талын зөргөөр харайж дэгдэн хурдлав.

Хоббитууд үг солих ч завгүй, гайхах ч завдалгүй араас нь яарав.

Яараад яараад гүйцсэнгүй. Том нүднээс далд орж, дуу нь улам улам намссаар. Тэгснээ гэнэт асгаран халих мэт чангарав:

Тогжгорууд минь хурдлаарай, харанхуй боллоо!

Том урд чинь явж гэрэл гаргана.

Шөнө ойртож, харанхуй салхи үлээнэ,

Шилэн цонх гэрэлтэж замыг чинь гийгүүлнэ.

Хар нарс, могой мэт мөчрөөс бүү айгаарай,

Хамаг хурдаараа араас минь дагаарай

Хаалгаа бид сайтар хаана, хөшгөө татна.

Харанхуй мөнхийн ой манайд орж чадахгүй.

Урьдын адил нам гүм, нар моддын цаагуур далд оров. Хоббитууд Брендидиумд өнгөрүүлсэн үдэш, Хоромины гэрлийг санав. Урд нь аварга том моднууд, асар том мөчрүүд, өтгөн бараан навчис. Голоос цагаан манан хөөрч, үдшийн бүрийтэй сүлэлдэн хөл дор хөглөрнө.

Явахад улам бэрх болж, хоббитууд ихэд ядран, хөл нь тугалга цутгасан мэт хүндэрч байв. Бут, зэгсэн дундуур араас нь хачин дуу авиа даган гүйж, моднуудын дооглонгуй зэвүүн төрх тэдний харцтай мөргөлдөн байв. Тэд бараг өөрийн ухаангүй юм шиг таамгаар явах бөгөөд ойн ид шид төгсгөлгүй мэт, энэ муухай зүүднээс сэрэхгүй юм шиг санагдаж байв.

Жим гэнэт тэднийг уул өөд зугуухан хөтөлж эхлэхэд тэдний хөл аяндаа нугарч байлаа. Найрсгаар долгилох усны чимээ сонсдож, хөөс цацруулсан жижигхэн хүрхрээ харанхуйд цайрч харагдав. Модод цаашилж, манан холдон мөлхөв. Тэд ойгоос уудам өвсөрхөг толгод руу гарч ирэв. Гол түргэн урсгалт горхи болж, тэдний өмнөөс шоржигнон гүйхдээ оддын гэрэл тусган гялалзана.

Хөл дор намхан торгомсог өвс байгааг бодвол хадсан бололтой. Тайрмал модод амьд хашаа болон эгнэжээ. Тахирласан жим чулуугаар хашсан тэгш зам боллоо. Зам тэднийг оддын зэгэл гэрлээр гийсэн толгойн оройд гаргахад нэлээд хол налуу өндөрлөг дээр байшингийн цонх гэрэлтэж харагдав. Зам тэднийг нэг дээш өгсүүлж, нэг доош уруудуулсаар нээлттэй хаалганы шаравтар гэрэл харагдлаа. Дараачийн толгойн бэлд Том Бомбадилын байшин байна. Тэр толгой руу бууж ирэхэд эгц нүцгэн хадан цохио дүнсийж, тэртээ алсад Булшийн толгод харлан үзэгдэв. Ядаргаа ор мөргүй алга болж, айдас ч дарагдлаа. Урдаас нь дуу цангинаж байна:

Торжигнотол алхаарай, бүү эмээгээрэй!

Тожгоруудыг Алтангаа урьж байна.

Томтой хамт үүдэндээ хүлээж байна.

Түргэлээрэй, бид та нарт дуулж өгье!

Дараа нь өвлийн агаар мэт цэвэр тунгалаг, өглөөн нарны туяа мэт өнгө солонгоруулсан өөр нэг хоолой залгаж авлаа:

Түргэлээрэй! бид та нарт дуулж өгье:

Өвсний шүүдэр, мөрөн гол, баясгалант бороо

Өргөн тал, өндөр уул, уудам хөндийн тухай

Өндөр зуны тэнгэр, ойн нуур цөөрмийн тухай

Мөчир, навчсын дусал, өвлийн тэсгим хүйтэн

Мандах нар, үүрийн гэгээ, нар сарны тухай

Ертөнц дээрх юм бүхний тухай хамтдаа дуулья!

Хоббитууд хурц гэрлээр гийсэн босгонд тулав.

Бүлэг 7

Том Бомбадилынд

Дорвон хоббит өргөн чулуун босго даваад нүдээ цавчлан нам зогсов. Тэд бараан өнгийн гялгар тавиуртай урт урт лаанууд, дүүжин дэнлүүгээр гэрэлтүүлсэн намхан адартай ч уужим өргөөнд ороод ирсэн байлаа. Өргөөний цаад буланд хаалга руу харсан буйдан сандал дээр гэрийн эзэгтэй сууж байв. Түүний цагаан шаргал үс мөрөн дээр нь намиран бууж нурууг нь бүтээсэн байх бөгөөд төл бургаас шиг энхрий ногоон өмсгөл бүсгүй биеийн гоо үзэсгэлэнг тодруулан тод цэнхэр уул цэцгээр чимсэн алтан бүс бэлхүүсийг нь чимж, эргэн тойронд нь ногоон, хүрэн өнгийн тавиурууд дээр усан лянхуа цэцгүүд хөвж байх нь эзэгтэй нуурын мандал дээр сууж байгаа мэт харагдуулна.

- Орцгоо эрхэм зочид минь- гэж бүсгүй саяны дуулсан цэвэр тунгалаг хоолойгоор урив.

Мань дөрвөн хоббит замын хажуугийн ердийн байшингийн хаалга тогшиж, уух юм гуйх гэтэл цэцгэн өмсгөлтэй үзэсгэлэнт эльф бүсгүй үүдээ нээсэн мэт эв хавгүй бөгөөд доор мэхийн ёслоод дотогш орлоо. Тэднийг үг ч дуугарч амжаагүй байтал эзэгтэй гоёмсог цэцэгсийн дээгүүр харайн, инээд алдсаар тэдэн рүү ирэхэд өмсгөл нь нуурын зэгэс сэвэлзүүр салхинаа исгэрэх мэт сэрчигнэж байв.

- Зоригтойхон бай эрхэм андууд минь, инээцгээ, хөгжилдөцгөө! Би голын хатан хаан Алтангаа байна – гэж эзэгтэй өөрийгөө танилцууллаа.

Тэднийг хажуугаараа өнгөрүүлээд, хаалганы цаадах шөнийг уран цагаан гарынхаа уяхан сэвэлтээр холдуулснаа эргэж харлаа.

- Шөнө ойдоо үлдэг! – гэж тэр хэлээд - Та нар одоо ч гэсэн өтгөн манан, хар моднууд, булан тохой, ойн үл мэдэгдэх хачин амьтдаас айж байгаа биз дээ? Бүү ай!, айдас огт хэрэггүй. Та нар одоо Том Бомбадилын найдвартай дээвэр дор байна.

Мань дөрөв босгоны дэргэд бороонд норсон ямаа шиг бээцийн зогссон хэвээрээ, эзэгтэй тэднийг инээмсэглэн ажиглана. Эцэст нь Фродо:

- Үзэсгэлэнт хатагтай Алтангаа – гэж ер бусын их бахдалд автсандаа арайхийн дуугарав. Урьд нь тэр дур булаам эльф дуу хоолой сонсоод амьсгаа давчталаа бахдан биширч байсан удаа бий боловч энэ удаа огт өөр, баяр бахдал түүний цээжийг давчдуулах биш, харин ч зүрхийг нь ээж, гайхамшиг түүнд харийн юм шиг санагдсангүй.

- Гайхамшигийн дээд хатагтай минь, таны дууны нууцлаг баяр баясгалан надад нэгэнт ойлгомжтой боллоо гэснээ гэнэт шүлэглэж эхлэв:

Нууцлаг гоо үзэсгэлэн, мөрөн голын цэвэр

охин минь

Нуурын зэгэс, тунгалаг горхины шулганаан минь

Хавар, зун, гэгээн гэрлийн дүү минь

Жавар, салхин дусал, зуны өдрийн инээмсэглэл минь

Тэгээд өөртөө гайхаж ээрэхэд Алтангаа хөгжилтэй инээж:

- Тавтай морилогтун! Хоббитанд ийм хэлэмгий хоббитууд байдаг гэж мэдээгүй шүү.

Гэвч чи эльфүүдтэй найз юм байна. Нүд чинь гэгээн тунгалаг, дуу хоолой чинь чанга юм байна. Та нар манай энд хүрээд ирсэн нь ямар сайн хэрэг вэ. За сууцгаа! гэрийн эзэн одоо ороод ирнэ, морьдод тэжээл өгч байгаа, тэд та нараас багагүй ядарсан – гэлээ.

Хоббитууд хөлөө ч мэдрэх тэнхэлгүй болсон тул намхан бургаасан буйдан дээр дуртай нь аргагүй суулаа. Алтангаа ширээ засч, мань дөрөв түүнээс нүд салгаж чадахгүй, түүний хөдөлгөөн бүхний бүжиг мэт уран гоог бишрэн суулаа. Хашаан дотроос хөгжилтэй дуун хадна. Урьд нь сонссон ойлгомжгүй үгс дахин дахин давтагдахаас гадна дахилт нь тод байв:

Цэнхэр хүрэмтэйгээ, шар гуталтайгаа

Цагаа олж эдэн дээр очсон Том чи мундаг

- Гоо үзэсгэлэнгийн дээд хатагтай минь, миний асуулт тэнэг байж болох авч Том Бомбадил гэж хэн юм бэ, хэлээд өгөөч? – гэж Фродо асуув.

- Байгаа нь л тэр – гэж Алтангаа түүн рүү эргэж хараад инээмсэглэв.

Фродо асуусан харц чулуудахад:

- Та нар дээр очихдоо ямар байсан, тийм л хүн. Тэр эндхийн юм бүхний эзэн. Ой, гол ус, уул толгод, талд хөндий бүгд түүний эрхэнд байдаг юм.

- Тэгэхлээр энэ орны эзэн хаан байх нь ээ?

- Үгүй дээ, - гээд эзэгтэйн инээмсэглэл бүүдгэрч - ямар хэцүү байдаг гээч - гэж аяархан, бараг өөртөө хэлээд – манай эндхийн ургамал, мод бут бүгд өөрөө өөрийнхөөрөө амьдардаг, тэдэнд хэний ч тушаал заавар хэрэггүй. Том Бомбадил бол бүх эздийн эзэн. Тэр хэний ч мэдэхгүй бүх жим, гарцыг мэднэ, ойгоор зугаалж, гэгээн өдөр, харанхуй шөнөөр толгодын дунд бүжиглэж байдаг, хэн ч юугаар ч түүнд саад болж чадахгүй. Өвгөн Том Бомбадил юунаас ч айдаггүй, тэр энд мөнхийн эзэн.

Хаалга нээгдэж том Бомбадил орж ирэв. Тэр малгайгүй, өтгөн буржгар үстэй зулай дээрээ улаан шаргал навчсан титэм тавьжээ. Том инээгээд Алтангаа руу очиж, гараас нь барилаа.

- За, миний эзэгтэй маргад эрдэнийн өмсгөлтэйгээ энэ зогсч байна. Бүх юм нь ногоон мөнгө, оддын очистой. Ширээн дээр ахиухан лаа асаагаарай эзэгтэй минь! Хөшгөө хаачихья, сайхан

хоол зооглож байхад үдэш хурдан өнгөрдөг юм. Ширээ зассан уу?, оройн зоог хүлээж байна уу? Сүү, өрөм, цагаан талх, шаргал бал- бүгд гайхамшигтай сайхан!

- Ширээ зассаан, харин зочид маань оройн хоолонд бэлэн байна уу?- гэж эзэгтэй хэлэхэд Том алгаа ташаад өөртөө хөгжилтэйгээ гайхаж:

- Өө маанаг! Мөн яарав аа! Оройн хоолонд урьж байдаг! Бүжингүүд үхлээ ядарсан, угаалга хийх хэрэгтэй шүү дээ. За эрхмүүд минь наашаа ирцгээ! Саван байна, ус байна. Цуваа тайлцгаа, угаацгаа!

Тэр танхимын гүн дэх үл ажиглагдам хаалгыг нээхэд хоббитууд араас нь дагаж оров. Богинохон коридор, булангийн цаана налуу таазтай залгаа өрөө байна. Засмал чулуун ханын дагуу ногоон өнгийн сүрлэн сүлжмэл хөшиг, шар өнгийн хивс өлгөсөн байх бөгөөд чулуун шалан дээгүүр шинэхэн бургаас дэвсчээ. Нэг ханын дагуу дөрвөн зузаан сүрлэн чихмэл гудас, ор дэрний хэрэгсэл эгнүүлэн тавьсан байх ба нөгөө ханын дагуу урт өргөн вандан, түүн дээр шавар ваар, хүрэн домботой халуун, хүйтэн ус тавьжээ. Ор бүрийн урд зөөлөн ногоон улавч байна. Төдөлгүй угаалга хийж, сэргэсэн хоббитууд ширээний хоёр талаар хоёр хоёроороо сууж, ширээний толгой талд гэрийн эзэн, эсрэг талд нь эзэгтэй сууж байв. Удаан бөгөөд хөгжилтэй хооллолоо. Өлсч ундаассан хоббитууд хоёр завьжаа түнтийлгэн идсээр байсан боловч бяслаг, цөцгий, талх, бал, жимс, ногоо хангалттай их байлаа. Тэд өөрсдийнхөө аягаар болор тунгалаг ус ууж байсан боловч тэр нь дарснаас илүүгээр хэл ээдрүүлж, зүрх хөөрүүлж байв. Нэг мэдсэн чинь тэд ярьснаас дуулсан нь амархан юм байна гэсэн шиг хоолой мэдэн дуулж байв.

Эцэст нь Алтангаа, Том хоёр босч ширээгээ хураалаа. Зочдын ядарсан хөлийг нь намхан сандал дээр тавиулан задгай зуухны дэргэд суулгав. Том задгай зууханд гал цоролзон их л амттай утаа үнэртэхийг бодвол алимын мод түлсэн бололтой. Дараа нь галаа унтрааж, зуухны тавиур дээр дөрвөн лаа асаав. Тэгээд гартаа лаа барьсан Алтангаа тэдний өмнө ирж бүгдэд нь сайхан унтаж, амттай зүүд зүүдлэхийг ерөөв.

Өглөө болтол амар, ойн нүргээн, шөнийн чимээнээс бүү эмээ! Манай хаалгыг зөвхөн толгодын зүгээс үлээх салхи сэвшиж, сар, оддын гэрэл нэвтэрдэг юм гэлээ.

Тэгээд шөнийн нам гүмд сэрүүхэн чулуун дээгүүр горхи урсах мэт сэрчигнэсээр яваад өгөв.

Том тэдэнтэй үлдээд дуугүй сууж байхад нь мань дөрөв хоолны ширээнд сууж байхдаа асуух гэж хүссэн зүйлүүдээсээ заримыг нь асуух зориг оров. Тэдний зовхи анилдаж байсан ч Фродо эхэлж дуугарлаа:

- Эзэн та миний хашгирахыг сонссон уу, зүгээр л дэргэдүүр гарч яваад туслахаар очсон уу?

Том амтат зүүднээсээ сэрсэн юм шиг цочисхийв.

- Юу? Туслах гэж үү? Үгүй дээ, сонсоогүй, би голын хажуугийн зөргөөр гэртээ харих гээд л дуулж явсан... Ер нь чиний тухай бол урьд нь мэдэж байсан, хоббит туулайнууд ой руу тохиолдлоор ороогүй, тэгээд ч одоо бүх жим далдуур Бургаст руу хөтөлж байгаа. Хөгшин

нарс аянчдыг хөнөөх гэж тийш нь татдаг юм... тэгэхээр би ойн жим дээр... юу хүссэн байх вэ?... Түүний нойр хүрч, дахиад л тонголзож эхэлсэн боловч яриагаа бүр уянгалуулан үргэлжлүүлэв:

Би тэнд усан лянхуа түүж явсан юм

Бэлэг болгож Алтангаадаа өгөх гэсэн юм.

Эхнэрийн минь дэргэд ирэх зун хүртэл

цэцэглэг гэж

Эхний цаснаас өмнө дандаа би түүдэг юм.

Хүйтний алганд хөлдөөчихгүйн тулд би

Хөх нуурын тунгалаг мандлаас түүдэг юм.

Энэ нуурын эрэгт эрт цагт би

Эхнэрээ хаврын эхэн сард олсон юм.

Зэгсэн дунд энэ маань дуулж суусан юм.

Зэвэргэн салхи дээгүүр нь хүүгэж байсан юм.

Том нүдээ нээхэд харцанд нь цэнхэр туяа

татаж байв.

Тэгэхлээр найзууд минь би Бургаст голд

Тийм хурдан очихгүй, хойтон хавар л байх.

Хөгшин модтой би хаврын сүүл сард

Хөгжилтэй навчис нь дэлгэрэх үед уулзана.

Эхнэр минь тэр цагт уснаа шумбахаар

Эрдэнийн бүжгээ бүжиж гол руугаа очно.

Том дахиад л дуугүй болоход Фродо тэсч чадсангүй хамгийн гол асуултаа асуув:

- Эзэн минь та бидэнд тэр аймшигт модны тухай ярьж өгөөч! Тэр хэн юм бэ? Урьд өмнө би түүний тухай сонсч байгаагүй.

- Үгүй ээ, хэрэггүй, одоо хэрэггүй, өглөө ярь – гэж Мерри, Пин хоёр нэгэн дуугаар гуйв.

- Зүйтэй, та нар амарсан нь дээр, шөнө тийм юм ярих цаг биш. Туулайнууд минь тайван унтацгаа, хөгшин моднуудаас бүү ай, шөнийн чимээнээс ч бүү ай – гэж Том хэлээд тэр гэрэл унтрааж, хоёр гартаа лаа бариад тэднийг унтах өрөөнд нь хүргэж өгөв.

Гудас, дэр нь зөөлнөөс зөөлөн, хоббитууд цагаан ноосон хөнжил нөмрөөд дэрэн дээр толгой тавингуут нам унтав.

Фродо хэцүүхэн зүүд зүүдлэв. Зүүдэнд нь шинэхэн сар дээш хөөрч, түүний цайвар гэрэлд өмнө нь хонгил бүхий өндөр хадан цохио сүндэрлэх шиг. Тэгснээ өөрийг нь дээш хөөргөж, нэг цохио биш, өчнөөн олон цохио, хясаа, харанхуй өндөрлөг, сэргэр хана хэрэм, хар цамхаг, түүн дээр хэн нэгэн зогсч байх шиг. Шинэ саран зориг муутайхан гэрэлтүүлж, зөвхөн харанхуй хар цамхаг, дээр нь байгаа цайвар дүрс хоёр л харагдана. Доор нь зэрлэг дуу хадаж, чононууд хилэнтэйгээ архиралдана. Сарны цаанаас гэнэт нүсэр хар сүүдэр гарч ирэхэд цамхаг дээр байсан дүрс гараа өргөж, нүд гялбам хурц гэрлээр харвалаа. Бүргэдийн далавч агаар зүсэн, доор чононууд ульж, араа соёогоо тачигнуулна. Салхи дорно зүгээс, дорно зүгээс, дорно зүгээс улайран түг түгхийх туурайн чимээ авчирна. “Хар морьтнууд” гэж Фродо мэдээд хүйтэн хөлс нь асгаран сэрэв. Шанааны судас алхаар хурдан хурдан цохих мэт оволзож байв. “Би энэ ханыг орхих зориг над бий гэж үү?”. Тэр амьсгаа даран хэвтэхэд нам гүм боллоо. Эцэст нь цагариглан хэвтээд нам унтав.

Түүний дэргэд Пин амттайхан нойронд умбан байснаа гэнэт амьсгал нь боогдох шиг болж, эргэж хөрвөн ёолов. Тэгснээ гэнэт сэрсэн үү, сэрэх шиг болсон уу харанхуй дунд “пыт-пыт”, “ы-ыхх-ыхы” гэх авиа сонсдож, хэн нэгэн мөрүүдийг хооронд нь үрж, хана, цонхыг модон хумсаар “скырлы, скырлы, скырлы” хэмээн маажиж байх шиг. Нарснууд байшингийн дэргэд хүрээд ирсэн юм байна гэж нойрмоглон бодтол өөрөө байшинд биш, хөгшин нарсны өмхөрсөн голд байгаа юм шиг, толгой дээр нь хөгшин, зэвүүн инээд сонсдож байх шиг. Тэр өндийж суугаад, зөөлөн дэрэн дээр тохойлдсоноо санаа амар дэрлэн хэвтээд өгөв. Чихэнд нь Алтангаагийн “Ойн нүргээн, шөнийн чимээнээс бүү ай, өглөө болтол амар” гэсэн үг намуухан цуурайлж, амтат нойрондоо дахин автлаа.

Мерри тавтай унтаж байтал усны чимээ тавгүйтүүлэв. Ус аяархан тамшаалж, ханыг сорох мэт, байшинг тойрон харанхуй, хязгааргүй, тогтоол нуур болон хальж, мөлхөж байна. Ус хананд тулан долгилж, булингартан нэмэгдсээр байлаа. “Би живэх нь. Ус нэвтрээд ороод ирнэ, халиад ороод ирнэ, бүгдийг живүүлнэ, намайг ч гэсэн” гэж Мерри бодлоо. Тэгээд живж эхлэхэд босон харайж, хөлөөрөө хатуу чулуун шал цохингуут хаана байгаагаа санаж эргэж хэвлээ. “Манай хаалгыг толгодоос үлээх салхи сэвшиж, цонхоор зөвхөн сар, оддын гэрэл л ордог юм. Сайхан нойрсоорой” гэх намуухан дуу сонсогдов уу, санагдав уу, Мерри гүнээ санаа алдаад нойрондоо дарагдав.

Сэм шөнийн турш нэг ч сэрэлгүй, гуалин мэт нам унтжээ. Гуалин сэрдэггүй юм чинь.

Өглөө дөрвүүлээ зэрэг сэрлээ. Том өрөөн дундуур холхиж, тодол шувуу шиг шагширч байв. Тэднийг сэрэхэд Том алгаа ташаад “Эй, дуулцгаа, хөгжилдөцгөө, байдаг хоолойгоороо дуул!” гэв. Тэгээд шар хөшгөө нээхэд баруун, зүүн талын өргөн цонхоор гэрэл мэлсхийн орж ирлээ.

Хоббитууд баяртайяа ухасхийн босов. Фродо зүүн цонхон дээр очоод өглөөний шүүдэрт

бүдэг саарал өнгөтэй болсон арын хашаа руу харав. Тэр цонх газартай нэг түвшинд, газар дээр туурайн мөр харахаас айжээ. Гэтэл цонхыг вандуйн хэлхээгээр хаасан байх бөгөөд цаана нь өндөр саарал толгой өглөөний гэрэлд дүнхийж харагдана. Өглөөний царай цонхигор, дорно зүгт улаан эмжээртэй урт хөвөн үүлний цаанаас шаргал гэгээ тусч байна. Намссан тэнгэр бороо зарлаж байсан ч өглөөний туяа улам хурц болж, нойтон ногоон навчнууд дунд цэцэглэж буй шош тод улайран байна.

Пин баруун цонхоор харахад өмнө нь манан бөөгнөрчээ. Ойг бүдэг саарал хөшиг хааж, саарал үүлэн дээрээс харж байгаа юм шиг санагдана. Ойн гүн рүү бөөн бөөн манан хөөргөсөн маш том жалга орсон байна. Тэнд Бургаст голын хөндий байгаа. Толгойн зүүн талаас эх авсан горхи цайвар манан руу орж байна. Цонхон дор цэцэглэж буй цэцэрлэг, цэцэрлэгийн саарал хайс, шүүдэрт мөнгөрсөн зүлэг байна. Ойр хавьд нэг ч мод алга.

- Өглөөний мэнд багачууд аа! – гэж Том дуудаад – одоохондоо нар алга. Баруун талаас үүлс гарч ирээд тэнгэрийг хаачихлаа. Мөдхөн бороо орно. Их устай, эрч хүчтэй орно доо, Алтангаад намрын цэвэрлэгээ хийхэд нь тус болно. Би түүнийг үүрээр хөгжилтэй дуугаараа босгочихсон. Унтаахай хүнд жаргал үгүй. “Эртэч шувуухай цадталаа иднэ, унтаж хоцорсонд нь ус, өвс хоёр л үлдэнэ” гэж үг байдаг даа.

Хоббитууд өвс, ус хоёр гэдэг үгэнд нэг их итгээгүй боловч юу ч гэсэн өглөөний хоолноос цааргалсангүй, бага багаар идсээр ширээг хоослох хүртлээ сайхан хооллов. Гэрийн эзэд хоолны ширээнд суусангүй. Том гэрийн ажлаа амжуулж, гал тогооноос сав суулганы чимээ, шатан дээрээс гутлынх нь чимээ сонсдож, нээлттэй цонхоор дууных нь мөрүүд орж ирнэ. Нээлттэй цонх баруун зүг хар, тэртээ алс хүртэл манант хөндий үргэлжилнэ. Өтгөн навчис шүүдэр цуглуулан дааж ядахдаа газарт ганц нэгээр дуслуулна. Үүлс тэнгэрийг бага багаар бүрхсээр бүрэн бүрхэж, ханан хар ойг бороон хөшгөөр халхлав.

Борооны жигдхэн чимээн дунд хаа нэгтээ ойролцоох толгодоос Алтангаагийн цэвэр тунгалаг хоолой сонсдоно. Дууны үг нь чихэнд баригдахгүй боловч намрын үерээр хальж, гол мөрний аялгуут дууль, бүхнийг ялагч амьдралын эрч хүчээр уулын горхиноос алсын тэнгис хүртэл цалгилж байгаа нь ойлгомжтой байлаа. Фродо цонх руу очоод долгилсон аялгууг бахдан сонсч, бороот өдөр, санамсаргүй сааталд баярлан байв. Цаашаа явах хэрэгтэй, яарах хэрэгтэй, гэхдээ өнөөдөр л биш.

Баруунтаагаас хүчтэй салхи эрчлэн ирж, хүнд саарал үүлсийг хөдөлгөхөд үүлс цааш явах тэнхэл алдаж, Булшийн Толгод дээр юүлэв. Байшингийн өмнөх цагаан шохойн чулуун зам сүүн гол болж, хөөсрөн урссаар усан хөшигний цаагуур орж байлаа. Булангийн цаанаас Том гүйн гарч ирлээ. Тэр бороог гараараа удирдаж байх шиг, үнэхээр тэр өөрөө хув хуурай, зөвхөн гутлаа тайлж задгай зуухны торон дээр тавилаа. Дараа нь том буйдан сандалд суугаад хоббитуудыг дуудав.

- Алтангаа жилийнхээ цэвэрлэгээг хийж байна. Бороо асгаж, хаа сайгүй ус, бүх юм норсон. Та нар явж болохгүй, хаа нэгтээ живчихнэ. Нэг өдөр хүлээж, Томтой хамт сууцгаа. Намар бол цаг агаар мууддаг үе, ярьж хөөрч, асууж шалгаадаг цаг... Том их юм мэднэ. Том эхлээд та нарт бороон шивнээн дор эртний түүх ярьж өгье, асуултаа дараа нь болоорой.

Тэгээд тэр олон сонирхолтой түүх ярьсан бөгөөд заримдаа өөрөө өөртэйгээ ярьж байгаа юм шиг байснаа гэнэт тэдэн рүү хурц цэнхэр нүдээрээ цоо ширтэн ярьж байв. Яриа нь байн байн нэгэн айзам хэмнэлт дуу болж хувирна, заримдаа босон харайж, дэндүү цоглог бүжиглэж гарна. Тэр зөгийний тухай, шинэхэн балын өнгөний тухай, өвс ургамлын тухай, тэнгэр хаасан аварга моддын тухай нэвтэршгүй ширэнгэ, өргөст бутнуудын тухай, үзэгдээгүй шувууд, газрын ер бусын амьтдын тухай, сайн болон муу санаат, харанхуй болон гэгээн хүчний тухай ярив.

Тэд сонссор байтал ой тэдэнд өмнөхөөсөө огт өөрөөр төсөөлөгдөж, өөрсдийгөө залхуутай урилгагүй харийнхан гэдгийг ойлгов. Эрх дархтай, хүчирхэг, хатуу шийтгэдэг Хөгшин Нарсны нэр шууд болон тойруу замаар гарч байв. Фродо гайхамшигтайгаар аварсан хувь заяандаа талархаж суулаа.

Мөнхийн ой гэж зүгээр нэг нэрлээгүй юм байна. Тэр бол нэгэн цагт дэлхийг нэлд нь бүрхэж байсан эртний их ойн сүүлчийн тасархай ажээ. Өнөөгийн моддын элэнц эцгүүд тэр их ойд хүчээ авч, уулсын адил хөгшрөхдөө газар дэлхийг хязгааргүй эрх дархаар эзэгнэж байсан тэр цагийг санасаар байдаг ажгуу. Тоогүй олон он жилүүд тэднийг хүчиндээ эрдсэн бардамнал, мэргэн ухаан, өшөө хорслоор цэнэглэжээ. Үжирсэн зүрхтэй боловч үрэн таран хийгээгүй баатрын их чадалтай Хөгшин Нарснаас аюултай нь үгүй, тэр хэрцгий, зальтай, салхи болон голын хоёр талыг захирдаг ажээ. Тэр үржил шимт хөрсний шүүсийг цадаж ханахаа мэдэхгүй сорж, саарал аалзны тор мэт үндсээ газраар нэг мөлхүүлэн, муруй саарал гараа тал тал тийш сарвайж, Ханан Хэрмийн наадах ойгоос өмнөд нуруу хүртэлх ойг эрхэндээ оруулжээ...

Дараа нь ойг мартаж, Томын яриа хөөс хаялан цовхочсон ширүүн урсгалт голын дагуу, хөөсрөх хүрхрээний хажуугаар, үелэн давхарласан хадан цохио, эгц чулуун асгаар өгсч уулын оргилд хүрэв. Хоббитууд Их Булш болон чулуу шүдэлж хийсэн цагаан титэм бүхий ногоон толгодын тухай, толгодын хоорондох нууц гүн дэх газар агуйн тухай сонсов. Өндөр өндөр хана босгож хүчирхэг цайзууд сүндэрлүүлэн, тэдгээрийн эзэд бие биетэйгээ улайран дайсагналцаж, цусанд шунасан жадны үзүүрт шинэхэн нар улайран гялалздаг байв. Ялалт ялагдлаар солигдож, цамхгууд пижигнэтэл нурж, бардам шилтгээнүүд авалцан шатаж, гал түймэр тэнгэрт тулан оволзож байв. Үхсэн хаадын авсан дээр алт асгаж, чулуун хонгилуудыг хааж, дээрээс нь шороогоор булан ялагдсан хаадын булшин дээр өтгөн өвс ургаж байлаа. Дорноос нүүдэлчид ирж, дахиад л булшнуудын дээгүүр хонь майлан, дахиад л үгүйрэл ойртож байв. Алс хязгаараас Дийлдэшгүй Харанхуй нөмрөн ирж, булшнуудад яс яйрч байлаа. Агуйнуудаар алт эрдэнэсийн бөгж, зүүлт шаржигнуулан сүг сүнснүүд тэнэж, чимээгүй толгодын дээрх цагаан чулуун титмүүд сулран ганхаж, сарны гэрэлд хугархай шүд мэт харагдаж байв.

Хоббитуудад аймшигтай болж эхлэв. Булшны толгод болон сүг сүүдрийн тухай домог Хоббитанд хүртэл яригддаг билээ. Хоббитанчууд тэдгээрийг сонсох дургүй байсан. Яах юм бэ? Тэр дөрөв бүгдээрээ гэрийнхээ задгай зуухыг нэгэн зэрэг санав. Томынх яг тийм боловч илүү бат бэх, илүү найдвартай юм. Тэд сонсохоо болиод суудал дээрээ сэмхэн хөдөлж, бие бие рүүгээ харав.

Тэдний айсан сонсголыг огт өөр түүх нээлээ. Тэр бол балар эртний, үл ойлгогдох үеийн түүх бөгөөд дэлхий ертөнц уудам, далай баруун эрэгт тулан давалгаалж, Том эртний оддын дор

дуугаа дуулж байсан үеийн түүх бөгөөд тэр үед эльфүүдээс өөр хэн ч байгаагүй гэнэ. Том гэнэт чимээгүй болж, үүрэглэж байгаа юм шиг тонголзож эхлэв. Хоббитууд илбэдүүлсэн юм шиг сууж байлаа. Томын ярианаас болж салхины амьсгаа тасраад, үүлс хайлж, өдөр алга болж цагаан цагаан гэрэлтэй гүн шөнө нөмөрчээ.

Өглөө болоод өнгөрсөн үү, үдэш болсон уу, нэг өдөр өнгөрсөн үү, олон өдөр өнгөрсөн үү Фродо ойлгосонгүй, ядрах, гэдэс өлсөх хоёроо ч мэдрэхгүй гайхаж суув. Том том цагаан одод цонхоор шагайж, амар жимэр, анир чимээгүй байлаа. Гайхаш нь гэнэт айдсаар солигдож Фродо:

- Ноёнтон, та хэн бэ? – гэж асуулаа.

- Би юу? Би түрүүн хэлсэн шүү дээ. Том балар эртнийх. Энд Том, газар, тэнгэр гурав балар эртнээс байсан. Гол, ой, ургамлаас өмнө, анхны бороо, анхны ган гачиг, айдас, хүчирхийллээс өмнө энд Том Бомбадил байсан, тэр энд дандаа байсан. Том бүгдийг санаж байна. Гайхамшигтууд гарч ирсэн, үхэлтнүүд гарч ирсэн, дайн, булшин дорх ёолоон... энэ бүхэн бүгд өчигдөр болсон... өнөөдөр зөвхөн Манант уулсын цаана, Галт уулын дээгүүр л харанхуй бүрхсэн.

Хар давалгаан цонх шавхуурдах мэт болоход хоббитууд цочиж, эргэн харвал Алтангаа тодхон гэрэлтэй лаа бариад, гэрлээ салхинаас алгаараа халхлахад гар нь ягаан сувдан дун мэт гэрэлтэн үүдэнд зогсч байлаа.

- Бороо зогсчихлоо. Оддын гэрэл дор толгодоос шинэхэн урсгал бууж байна. Инээж хөгжилдөж баярлацгаая – гэж тэр хэлэв.

- Баярлацгаая, идэцгээе, ууцгаая – гэж Том хөгжилтэй шүүрч аваад- Түүх хоолой хатааж байна, Том өглөөнөөс хойш ярьсан, туулайнууд сонссон. Ядраа биз дээ? Оройн хоолондоо!

Тэр ухасхийн задгай зуух дээрээс лаа аваад Алтангаагийн лаанаас асааж, ширээ тойрон бүжиглэснээ гүйн гарч, тэр дорхноо баахан хоол овоолсон том тавиур авчраад эхнэртэйгээ ширээ засч эхлэв. Хоббитууд бишүүрхэн биширч, бишүүрхэн инээж суув. Алтангаа дэндүү дур булаам сайхан, Том дэндүү инээдтэй тойрон харайж байлаа. Тэр цаг ямагт бүжиглэж байдаг бололтой, ширээ тойрон, хаалгаар орж гарахдаа хүртэл. Төдөлгүй том ширээ хоол, лаа хоёроор дүүрэв. Ханын гэрлүүд цагаан шаргал туяа цацруулна. Том зочдодоо мэхийн ёсолж, Алтангаа:

- Оройн хоол бэлэн боллоо – гэж зарлав. Тэр цагаан бүстэй ялдам мөнгөлөг өмсгөлтэй байхыг тэд анзаарав. Том уул цэцэгтэй цагаан цэнхэр өмсгөл хөдөрч, ногоон оймс углажээ.

Оройн хоол өчигдрийнхөөс ч арвин байлаа. Томын ярианд мансуураад хоббитууд хоолны тухай мартсан тул долоо хоног өлөн байсан юм шиг өмнөхөө хоосолж байлаа. Даанч сайхан хоол байсан тул дуу хуур, яриа хөөрөнд сатаарсангүй. Хагартлаа идэж, ханатлаа ууж аваад дуу хоолой нь цоглог болж, инээж хөгжилдөв.

Алтангаа олон дуу дууллаа. Цовоолог, намуухан дуунуудад нь гол урсч, нуур долгиолж, усны

мандалд одот тэнгэр хөвж байгааг тэд үзэв. Дараа нь тэр сайхан нойрсохыг ерөөгөөд задгай зуухны дэргэд орхилоо. Харин Том зүүрмэглэж байгаад сэрсэн мэт тэднийг шалгааж эхлэв.

Гайхалтай нь тэр хоббитуудын тухай бараг бүгдийг мэддэг, өвөг дээдсийг нь ч санаж байлаа. Хоббитан оронд хоббитууд төрөхөөс өмнө юу болж байсныг ч мэдэх ажээ. Төдөлгүй тэд гайхахаа ч болив... харин Том мөнөөх Зожигийг бүхнээс илүү дурсч байгаа нь хачин. Гэтэл тэд түүний тухай юу мэдэх билээ!

- Зожигийн гар газарт ээлтэй, хурдан ажилладаг мөртөө байнга анхааралтай ажиглаж байдаг. Тэр газар дээр багтай гишгэдэг, найгаж явдаг мөртөө хазгай гишгэсэн нь нэгээхэн ч үгүй – гэж Том ярилаа.

Том эльфүүдтэй эртний танил Фродогийн тухай хамгийн сүүлд Харальд ярьсан юм биш үү? Тэр ийм их юм мэддэг мөртөө тун зальтай асууж байсан учир Фродо Бильбогийн тухай өөрийнхөө найдвар, айдсын тухай бараг Гэндальфт ярьдгаасаа илүү ярьчих шиг болов. Том дуугүй толгой дохиж сууснаа хар морьтнуудын тухай ярихад нүд нь зальтай гялсхийв.

- Тэр “эрдэнэ”-ээ надад үзүүл дээ –гэхэд нь Фродо шууд л бөгжөө тайлан Томд өгөхдөө өөрөө ч гайхав.

Бөгж Томын бараан алган дээр эхлээд жижгэрснээ дараа нь томров. Том бөгжийг нүдэн дээрээ бариад нүхээр нь харан инээв. Алтан хүрээтэй хурц цэнхэр нүд хоббитуудад нэг талаар түгшүүртэй, нөгөө талаар инээдтэй харагдана. Том бөгжийг чигчий хуруундаа зүүгээд лаанд ойртуулав. Ойртуулаад л байна, ойртуулаад л байна, гэвч Том алга болсонгүй, хоббитууд халуун ус цацуулсан мэт зэрэг дуу алдав.

Том тачигнатал инээгээд бөгжийг тааз руу шидэхэд бөгж ууртай исгэрээд алга болов. Фродо сандран хашгиртал Том ширээн дээгүүр инээмсэглэн бөхийгөөд хаанаас ч юм гараад ирсэн бөгжийг түүнд өглөө.

Фродо бөгжийг ямар нэг илбэчинд зээлүүлчихээд буцааж авч байгаа юм шиг ширүүн дүртэй бөгөөд сэжигтэй үзлээ.

Бөгж урьдын адил хүнд байв. Яагаад ийм хүнд байдаг юм бол гэж Фродо үргэлж гайхдаг байсан юм. Бөгж Томыг яаж ч чадахгүй байдаг, гэтэл Гэндальф түүнийг аймшигтай чухал хэмээн ярьсан нь түүнд гомдолтой санагдав. Тэр жаахан хүлээж байгаад Том доргоны тухай ярьж эхлэхэд нь бөгжөө сэмхэн зүүчихэв.

Мерри түүн рүү санамсаргүй эргэж харснаа ихэд айж “Хааччихав? Яаж?” хашгирахаа арай ядан дарахад нь Фродо бүх юм хэвийн байна гэж бодоод баярлав. Бөгж жинхэнээрээ байгаа учраас Мерри түүний сандал руу мэл гайхан харж байна. Фродо сэмхэн босоод хаалга зүглэв.

- Юу болоод байна Фродо? Дүрсгүйгэхээ боль – гэж Том хурц, тайван, бүхнийг харагч цэнхэр нүдээ гялалзуулан хэлээд – Цагаан эрвээхэй шиг цайчихаж гэнэ!... Нааш ир! Наад тоглоомоо ав, түүнгүйгээр чи сайхан байна. Чимээгүй суу туулайнууд аа, маргааш та нар замд гарна. Их замд яаж хурдан хүрэхийг Том зааж өгнө. Төөрөхгүйн тулд сайн сонс!

Фродо аргагүйн эрхэнд инээгээд бөгжөө тайлж, суудалдаа суув.

Том маргааш нарлаг өдөр болно гээд - аль болохоор эрт гар, тэгэхгүй бол эндхийн цаг агаарыг Том ч урьдчилан хэлэх аргагүй, цаг агаарын ааш Алтангаагийн гоёлоос ч олон солигддог гэлээ.

Түүний зөвлөснөөр Булшийн толгодыг тойрон уулын баруун бэлээр хойд зүг явахаар шийдэв. Хэрэв аз тохиовол Их баруун замд нэг өдөр яваад хүрч болно. Том тэдэнд юунаас ч айхгүй байх, хэрэггүй юм руу саваагүйтэхгүй байхыг сануулав.

- Ногоон өвсөн дээгүүр, уулын бэлээр, Нойтон жалгаас холуур яв, тэнд хорон санаат манан, хуурдаг чулуу, үхдэл сүгийн газар байдаг юм. Том энэ үгээ хэд дахин давтаж хэлээд аль болохоор баруун талаа барьж яв гэж тушаав. Дараа нь тэд гай зовлон тохиолдвол Томыг дуудах дуудлагын дууг цээжлэв:

Яруухан дуу минь, Том Бомбадил руу нис,

Явдал замд нь эрж олоод хөөж гүйц,

Яалаа ч гэсэн түүнийг алс холоос авчир.

Туслаарай Бомбадил, бид аюулд учирлаа.

Тэд хамтдаа жаахан суугаад, Том бүгдийнх нь мөрөн дээр инээн алгадаад унтах өрөөнд нь хүргэж өгөв.

Бүлэг 8

Булшин дээгүүрх манан

Фродо зүүдлэлгүй унтлаа. Гэвч үүрээр зүүдэлсэн юм уу, бодитой болсон юм уу бүү мэд, борооны саарал хөшгийг дотроос нь гийгүүлэх мэт энхрий ялдам аялгуу сонсогдож, хөшиг мөнгөлөг шилэн өнгөтэй болж, алгуурхан нээгдэн өмнө нь нарны туяа гийсэн ногоон алс цэлийв.

Тэгээд л сэрчихлээ, Том босчихсон, шувууны үүрээр дүүрэн том мод мэт исгэрэн явж, толгодын цаанаас нар цухуйн, нээлттэй цонхоор туяагаа цацруулж байна.

Гадаа бүх юм ногоон, цайвар шаргал өнгөөр сүлэгдэн байна.

Мань дөрөв бас л гэрийн эзэдгүйгээр өглөөний хоолоо идэж, амандаа орсон болгоныг ярьж, гэрийн эзэдтэй салах ёс хийхээр бэлтгэв. Өглөө хичнээн цэвэр тунгалаг, цэнхэр, зөөлөн, аян замд урин дуудаж байсан ч сэтгэл зүрхэнд нэг л хүнд байв.

Морьд нь цовоо сэргэлэн гэж жигтэйхэн, харайж дүүлэх нь холгүй. Том үүдний довжоон дээр гараад малгайгаараа даллан бүжиглэж, цаг хэзээ ч хүлээдэггүй хэмээн сануулж байна. Хоббитууд санаа алдан гарч, эгц налуугийн дагуух жимээр яарч явтал Фродо гэнэт шийдэж ядах байртай зогсов:

- Алтангаа яах вэ? – гэж тэр дуу алдаад - Маргад эрдэнийн гялбаат сайхан бүсгүйгээ яах вэ? Бид чинь түүнтэй салах ёс хийгээгүй, өчигдрөөс хойш хараа ч үгүй шүү дээ!

Тэр бүр эргэх гэж байтал уянгалаг энхрий дуу хоолой сонсдов. Алтангаа өндөр гүвээн дээр зогсоод тэднийг дуудаж байна, үс нь салхинд долгиотон нарны гэрлийг солонгоруулна. Бүжиглэж байгаа хөлийнх нь дороос шүүдрийн дуслууд гялалзан үсчинэ.

Тэд налуу өөд өгсөн гүвээн дээр гараад амьсгаадан түүнийг тойрч зогсов. Түүнд мэхийн ёслоход тэр тийшээ хар гэж урин гараараа заав. Тэд өндөр дээрээс өглөөний газрыг харлаа. Тэднийг Мөнхийн ойн дээд хэсэгт байхад ертөнцийг бүрхэж асан нүсэр манан байгаагүй юм шиг алсын бараа цэлийтэл нээгдэж, бараан хүрээтэй цайвар ногоон газар харагдана. Ойт уулс нарны гэрэлд ногоон, шаргал, улаан шар өнгөөр туяаран алс Брендидиумын хөндийг хаан сүглийнэ. Өмнө зүгт Хоббитаны хамгийн том гол өөрийн усаа үл мэдэх хязгаар руу авч одсон Бургаст гялалзаж харагдана. Ногоон саарал, хүрэвтэр толгод умар зүгт намсан оджээ. Дорно зүг өглөөн наранд гийсэн чулуун өндөрлөгүүд давхарлан сүндэрлэж, утаархаг цагаан буданд далд орох бөгөөд хачирхалтай ой дуртгалаар ч юм уу, эртний домгоор ч юм уу тэдгээрийн цаана алсын уулсын оргилууд байгаа нь мэдэгдэнэ.

Тэд анхилуун агаараар ханатал амьсгалж, юунд ч торохгүйгээр хөлөө өргөх л юм бол хөл нь тэднийг хүрэх газарт нь хүргэх юм шиг санагдана. Их замын зүг жимээр шогших гомдолтой юм шиг санагдана. Том байхгүй байсан бол нэг-хоёр гээд л чулуу дамжин харайгаад хүрчих юм шиг санагдана.

Тэд салахын өмнө юу гэж хэлэхээ мэдэхгүй балмагдаж байтал Алтангаа өөрөө ярилаа:

- Яарцгаа найз нар минь, бодсоноосоо бүү ухар, шургуу зүтгэ! Умар зүг, зүүн хацраасаа салхитай, зүрхэндээ сайн ерөөлтэй яв! – гээд Фродод хандаж – Баяртай, эльфүүдийн найз минь, бид баяртай уулзсан, хөгжилтэй салъя!- гэв.

Фродо дуугарсангүй. Тэр доор мэхийн ёслоод морио хөтлөн түрүүлж, бусад нь араас нь дагав. Том Бомбадилын зочломтгой байшин, хөндий, Ой далд орлоо. Хонхор газарт чийглэг дулаахан, гандаж буй өтгөн өвс анхилуун үнэртэнэ. Тэд эргэж хараад Алтангаа тээр холд, жижигхэн, гоолиг, нарны туяа цацарсан цэцэг мэт зогсохыг үзэв. Тэр тэдэн рүү гараа сунган зогсч, үдэлтийн дуу нь цуурай татан, гараараа нэг даллаад эргэж толгойн цаагуур орлоо.

Жим тэднийг толгодын ногоон бэлээр доош хөтөлж, түрүүчийнхээс өргөн, гүн хонхор руу оруулаад дараа нь толгод, хонхор дамжуулан өгсүүлж уруудуулав. Мод ч байхгүй, гол горхи ч байхгүй, зөвхөн салхины сэмхэн шивнээ, шувуудын жиргээн сонсдоно. Нар улам дээш хөөрч, улам халуун боллоо.

Орой дээр гарах бүрт салхи намдаж байв. Баруун газар, алсын Ой тэдэнд дахин ил гарч ирэхэд одоо хүртэл борооны манан хэвээр байх шиг санагдав. Тэнгэрийн хаяа бараантаж, бүүдгэр хөх будан тэнгэрийг бүрхэн тэнгэрийн халуун нүдэн дээр халуун, хүнд жин тавьж байх шиг санагдана.

Үд болоход тэд том таваг шиг өргөн, хавтгай оройтой өндөрлөгт орж ирэв. Тавагны ёроолд салхи ч үгүй, тэнгэр улам намсана. Аянчид захад нь гарч ирээд хойд зүг рүү хараад хичнээн хол явснаа мэдлээ. Агаарын урсгал алсын харааг хааж байсан ч Жалга дуусч байгаа нь ойлгомжтой байв. Тэдний өмнө нэлээд нам дор хөндий байх бөгөөд цаана нь хоёр эгц налуу харагдана. Цаашаа толгод үгүй, бүдэг бараан зурвас л харагдана.

- Энэ бол модод. Их замын дагуу байгаа байх. Хэзээ ч юм суулгасан гэж ярьдаг юм – гэж Мерри тайлбарлав.

- Сайн байна, хэрэв бид орой болтол өдий хэмжээний газар хороовол Жалга ард үлдэнэ, тэнд хонох газраа олно – гэж Фродо хэлэв.

Ингэж хэлээд тэр зүүн зүг рүү хартал хавтгай оройтой ногоон толгод харагдах бөгөөд заримынх нь орой хоосон, заримаас нь хугархай шүд мэт цагаан чулуу цухуйж үзэгдэв.

Энэ бол сайны ёр биш байлаа, нөгөөх өвсөрхөг тавагны дунд ч бас тийм цагаан чулуу байсан шүү дээ. Үд дунд чулуу сүүдэр унагахгүй байсан ч амрахаар суусан хоббитуудын нуруунаас аятайхан сэрүүцүүлж байв. Ууж, идэж, ямар сайхан амттай юм бэ, Том ч гараа гаргаж дээ хэмээн баярлацгааж байлаа. Эмээлийг нь авсан пони морьд дэргэдүүр нь идээшилж байв.

Бэрх зам, сайхан хоол, нарны халуун, өвс ногооны үнэр. Хөлөө жийн тэнгэр харж хэвтсэнээс бүх юм эхлэв. Тэд унтаж сэрээд ихэд айв. Унтана гэж огт бодоогүй билээ. Чулуу хөрч, зүүн зүг рүү урт сүүдэр тусгаж байв. Бүүдгэр нарны гэрэл тал талаас хөөрч байгаа өтгөн цагаан мананг арай ядан нэвтэлж байв. Нам гүм, тунамал чийг. Морьд бөөгнөрөөд толгойгоо

унжуулав.

Хоббитууд яаран ухасхийж, толгойн баруун тал руу гүйв. Тэд бүдэг харанхуйн дундах бяцхан арал дээр байх шиг. Нар хүртэл цайвар мананд живж, зүүнээс хүйтэн саарал манан мөлхөж айсуй.

Манан, манан, манан, тэдний дээгүүр дээвэр болон хааж, чулуун баганатай мананд танхимд орсон шиг.

Байдлаас үзэхэд тэд отоонд орсон бололтой, гэхдээ сэтгэлээр унасангүй. Тэд замаа харж байсан, хаагуур явахаа мэдэж байсан. Энд үлдэж, мананг хүлээх тухай бодоо ч үгүй байсан.

Морьдоо хөтлөн толгойн хойд талын налуу руу манангийн тэнгист орж явчихлаа. Хамаг юм чийг дааж, үс хүртэл нойтон, наалдамхай болов. Доош буугаад цуваа өмстөл хоромхон зуурт чийг дааж хүндэрлээ. Морьд замаа арайхийн тэмтчин удаан алхана.

Яаж ийгээд хонхроос гарах хэрэгтэй. Тэгвэл шулуун явна, их зам хүртэл замаа алдахгүй. Жалганы цаана манан шингэрнэ, бүр арилж ч магадгүй гэж тэд найдаж байлаа.

Тун ч удаан урагшилж байлаа. Хоорондоо салахгүйн тулд нягт гинж болж, Фродо урьд нь, араас нь Сэм, Пин, Мерри явж байв. Жим төгсгөлгүй юм шиг санагдаж байтал гэнэт хоёр талаас түнэр харанхуй ойртож байхыг Фродо ажиглав. Тэгвэл энэ умард хавцал юм байна. Нойтон жалгыг өнгөрчихөж.

- Миний хойноос хурдлаарай! – гэж тэр хашгираад урагш тэмүүлэв. Гэтэл найдвар тэр дороо түгшүүрээр солигдож, хар хана нийлэв. Дараа нь цаашилж, тэдний өмнө хоёр асар том чулуун шүд гараад ирэв. Гарц бололтой, гэхдээ хаанаас гараад ирсэн нь ойлгомжгүй, дээрээс харагдаагүй шүү дээ. Фродо хоёр шүдний хоорондуур дайран гартал дээрээс нь харанхуй нөмөрч авлаа. Морь тургин цоройход Фродо газарт унаж, босоод иртэл ганцаараа, найзууд нь алга байгааг мэдэв.

- Сэм! Пин! Мерри! Наашаа, бүү хоцор!- гэж хашгирав.

Ямар ч хариугүй. Тэр айдаст автаж, арагшаа чулуун хаалгаар гүйн гарч: Сэм! Пин! Мерри! Та нар хаана байна!- гэж хашгирав. Морь нь ч нойтон манан дунд үзэгдэхгүй боллоо.

Хаа нэгтээгээс, зүүн талаас бололтой “ Хөөе, Фродо! Фродо! Эй!” – гэж хашгирах сонсдоход тэр зүг гүйн найз нараа дуудсаар. Эцэст нь “Фродо, эй! – Дээрээс, харанхуй дундаас нарийхан дуугаар дуудсанаа - Туслаарай! Туслаарай! Туслаарай!!” хэмээн бархирах дуулдахад дээшээ таамгаар, гүн харанхуй руу мацлаа.

Хөл дор гэнэт тэгшхэн болоход тэр толгойн орой дээр гарснаа ойлгов. Хөл гуйвж, бүх бие норж, даарсандаа чичирч байв. Нам гүм, харанхуй хоёроос өөр юу ч байдаггүй.

- Та нар хаана байна?

Хариу байдаггүй. Тэр дахин нэг хашгираад, болгоомжтой чагнав. Чихэнд хүйтэн салхи л

үлээнэ. Амнаас нь цагаан уур савсч байгааг Фродо анзаарав. Цаг агаар өөрчлөгдлөө. Манан урагдан хэсэг бусаг болж, харанхуй нимгэрэв. Фродоо дээш харвал үүлний цоорхойгоор бүдэг одод үзэгдэв. Салхи дахин үлээж, өвс шаржигнав.

Бөглүүд хашгирах дуу сонсдоход тэр зүг рүү гүйв. Манан хумигдан алга болж, одот тэнгэр ил гарав. Зүүн чиглэлийн салхи ясанд хүртэл жихүүцүүлнэ. Баруунаас Булшны толгой хар сүүдэртэн тодорлоо.

- Та нар хаана байна аа? – гэж айсан, уурласан дуугаар дахин хашгирав.

- Энд байна аа! энд байна, чамайг хүлээж байна!- гэж газар дороос зүрх зогсоом хүйтэн бөглүү дуу гарав.

- Үгүй - үгүй – гэж Фродо хэлсэн ч хөдөлж чадсангүй.

Түүний өвдөг нугарч, газарт унав. Чив чимээгүй, хэн ч байхгүй, хий юм сонссон юм болов уу? Тэр чичрэн нүдээ нээтэл дээрээс нь нэг хар дүрс бөхийж, хоёр үхмэл цацраг мэт мөсөн харцаар өөрийг нь газарт хадах мэт болж, бахим хүйтэн савар дарахад Фродо нүд ирмэх зуур толгойноосоо хөлөө хүртэл хөшиж ухаан алдав.

Фродо ухаан ороход айдсаас өөр бүх юм мартагдсан байв. Дараа нь гэнэт “баригдчихаж, булшинд байна, гүйцээ” гэсэн бодол зурсхийв. Үхдэл сүг барьж аваад илбэдсэн байна, одоо би Хоббитанд шивнэж ярихаас ч айдаг байсан хар шидийн эрхэнд байна гэж бодлоо. Тэр хөдлөхөөс ч айж, чулуун шалан дээр гараа цээжин дээрээ зөрүүлэн хэвтэж байлаа. Үхлийн айдаст хүлэгдэн, харанхуйд хөдөлгөөнгүй хэвтэж байхдаа тэр яагаад ч юм үхлийн тухай бодсонгүй, харин Бильбо, түүний яриаг санаж, хоёулаа Хоббитаны нарлаг хөндийнүүдээр зугаалж, аян зам, адал явдлын тухай ярьж явсан нь санагдлаа. Хамгийн баян, хамгийн ядуу ямар ч хоббитын дотор хар өдөрт нөөцөлсөн мэт эр зориг нуугдаж байдаг /заримдаа бүр гүнд нуугдаж байдаг/ юм. Фродо хамгийн баян ч биш, хамгийн ядуу ч биш боловч, өөрөө энэ тухай мэддэггүй байсан ч Бильбо, Гэндальф хоёр түүнийг Хоббитаны хамгийн шилдэг хоббит гэж мэддэг байсан юм. Түүний аяллаа дууссан, аймшигтайяа дууссан гэдгийг ойлгомгоц энэ ойлгоц нь түүнд эр зоригийг харамгүй өглөө. Фродо үхэх сэхэхийн тулаанд өөрийгөө бэлтгэлээ. Одоо тэр үхээнц дуулгавартай золиос аль хэдийн биш болсон байлаа.

Хүчээ хурааж байгаад тэр харанхуй дороос, чулуун шалан дороос гарч байгаа ногоовтор гэрлээс ухарч байгааг ажиглав. Хүйтэн долгионоор цацарч байгаа гэрэл нүүр болон биен дээгүүр нь тарж, хана, тааз хоёр урьдын хэвээр харанхуйд үлдсэнийг анзаарав. Фродо хажуу тийшээ хараад дэргэд нь Сэм, Пин, Мерри гурвуулаа нам хэвтэж байгааг үзэв. Тэд үхдэлийн цагаан өмсгөлтэй, үхдэлийн цонхигор өнгөтэй дээш харан хэвтэж байлаа. Тэдний эргэн тойронд алт эрдэнэс овоорч, жихүүдэс хүрэм бүдэг өнгөт алт булшны хумхийн тоос шиг санагдаж байв. Толгойд нь сувдан эрих өмсгөж, бугуйнд нь алтан гинж зүүн, хуруунуудыг нь эрдэнийн бөгжөөр гутаажээ. Гурвуулангийнх нь хоолой дээр хуйнаас нь сугалсан илд тавьжээ.

Дуу дуурсаж эхэлсэн нь удаан хэмнэлтэй, ойлгомжгүй, булшны дуу байлаа. Холын холоос гарсан, тэсэхийн аргагүй уйтгарт дуун газар дороос нэвчин гарч байв. Гашуудлын тэр дуунд

харгис хэрцгий, үхүүлэгч, эргүүлж буцаалтгүй үгс болон аажмаар цэгцлэгдэж байлаа. Ёолсон, гомдоллосон үгс. Өглөөг мөрөөдсөн шөнө өглөөд гомдол мэдүүлэх мэт, дулааныг санасан хүйтэн дулааныг хараан зүхэх мэт. Дуулал улам тод болж, зүрхэнд айдас хуруулам хараалын үгс тодров:

Хав харанхуй болтол,

Хамаг гэрэл, нар, сар, одод бөхтөл,

Хар эзэн ертөнцийг захирах хүртэл,

Харлаж бүүдгэрсэн тэнгэрт

Хав харанхуй нөмөртөл,

Харвах үүрийн гэгээнээс

Хадан доогуур яс бол!

Толгой дор нь нэг юм чихарч, торжигнов. Өндийж, тохойлдон хартал Булангийн цаанаас урт хар гар хуруугаа чилэмдэн Сэмийн хоолой дээр тавиатай байгаа илдийн бариул руу гэтэж байгааг харлаа. Аймшгийн хараал Фродогийн дээрээс дарж, эргэж харалгүй зугтаах хүсэлд автав. Бөгжөө зүүгээд л үхдэл сүгийн газраас үзэгдэлгүй гарч, гэрэлт ертөнцөд одно. Бөгжөө зүүгээд л, юунд ч харагдалгүйгээр гадагш гарна. Тэр өглөөн шүүдэрт өвсөн дээгүүр, Сэм, Пин, Мерри нарын хойноос гашуудан уйлсаар гүйж байгаагаа төсөөлөн бодлоо. Гэхдээ өөрөө амьд, аврагдсан. Гэндальф хүртэл түүнийг буруушаахгүй. Өөр яах байсан юм бэ?

Гэвч эр зориг түүнд өөрийг хэлж байлаа. Хоббитууд найз нараа гай зовлон дунд хаядаггүй. Гэхдээ л халаасан дотроо тэмтэрлээ... үхдэл сүгийн гар Сэмийн хоолойд улам ойртсоор. Гэнэтхэн шийдэмгий байдал дийлж, хажуудаа байсан богино илдийг шүүрч аваад өвдөг дээрээ босч, нөхдийнхөө биен дээгүүр тонгойж, гэтэж байгаа гарыг байдаг чадлаараа тас цавчлаа. Илд хугарч, ер бусын их орилох сонсдон, гэрэл бүдгэрэв. Харанхуйг заналт архираан донсолголоо.

Фродо Меррийн дээрээс унаж, хүйтэн нүүрийг нь хацраараа шүргэв. Гэнэт манангийн цаана, толгодын дээрх байшинд байснаа, Алтангаа, Томын дууг санав. Томын тэдэнд зааж өгсөн дуудлагын дууг ч санав. Итгэл муутай, чичирсэн хоолойгоор тэр дууг эхэллээ:

- Яруухан дуу минь, Том Бомбадил руу нис,-- энэ нэрийг хэлэнгүүт хоолой нь чангарч, бүрээ үлээж байгаа юм шиг бүхэн хүчээр цуурайтлаа:

Яруухан дуу минь, Том Бомбадил руу нис,

Явдал замд нь эрж олоод хөөж гүйц,

Яалаа ч гэсэн түүнийг алс холоос авчир.

Туслаарай Бомбадил, бид аюулд учирлаа.

Цуурай зогсч, нам гүм болоход зөвхөн Фродогийн зүрх бүдэгхэн цохилж байв. Удтал чимээгүй байснаа зузаан ханын цаанаас мэт, алсын толгодын цаанаас хариу дуу дуурьсаж, улам ойртсоор байв:

Хөөе, би Бомбадил, намайг харсан уу?

Хөл нь салхи адил хөнгөн шүү

Хөөж гүйцэх аргагүй шүү

Хөл нь шараас шар гуталтай

Хүрэм нь тэнгэрээс цэнхэр

Хөгжилтэй дуунаас нь илүү

Хүчтэн хаана ч байгаагүй, байх ч үгүй!

Чулуу шүүрдэх чимээ нүргээнтэй сонсдож, булшинд хурц гэрэл мэлсхийн тусч, хананд хагархай гарч, тэндээс Томын өдтэй малгай өмссөн толгой цухуйн араас нь улаан нар мандав. Хөдөлгөөнгүй хэвтэх гурван хоббитын нүүрэн дээгүүр нарны гэрэл гүйж, хүүрийн өнгийг нь арилгав. Тэр гурав одоо зүгээр л бөх гэгч унтаж байгаа харагдана.

Том мэхийн ёслоод малгайгаа авч, дуулан орж ирлээ:

Гэрэлт наран мандаж, хуурдаг чулуу унтлаа

Гүн ойн цэвдэг рүүгээ нис үхдэл сүг минь!

Эртний булшнууд үүрд цэвэршгэл

Эргэж ирэхгүй Хар уулын цаагуур тонил!

Үүрийн гэгээ нь хүртэл шөнөөс харанхуй

Үхдэл сүгийн ертөнцдөө очиж унт!

Түүний дуунд хариулж амь тэмцэн уртаар орилох чимээ сонсдоод, булшны гүний дээвэр нуран бутрахад нам гүм боллоо.

- За, булшнаас хурдан гар! – гэж Том тушаагаад бид бас гурван найзаа нарны гэрэлд гаргах хэрэгтэй- гэлээ.

Тэр хоёр Мерри, Пин, Сэм гурвыг дээш гаргалаа. Фродогийн нүдний буланд тас цавчигдсан сарвуу нуранги шороонд дутуу гишгүүлсэн аалз мэт сарвалзаж байх нь харагдаад өнгөрөв.

Том дүнгэнэсэн шуугиан, хөлийн чимээ сонсдож байсан хоосон хонхор руу эргэж ороод баахан зэр зэвсэг, хуучны хийцтэй, олон өнгийн эрдэнийн чулуутай алт, мөнгө, зэс, хүрэл гоёл чимэглэлүүд авч гарч ирээд булшны ногоон толгой дээрх нар туссан өвс ногоон дээгүүр тарааж шидэв.

Тэр Булшны толгойн бэлд хөдөлгөөнгүй хэвгэж байгаа гурван хоббит руу гартаа малгайгаа барин харж зогслоо. Дараа нь баруун гараа дээш өргөн чанга бөгөөд тушаангуй өнгөөр:

Хуурдаг чулуу сэршгүй унтлаа, босоцгоо туулайнууд аа!

Хурдалж араас чинь ирлээ Бомбадил, дулаацацгаа!

Хар хаалга дэлгээстэй, үхдэлийн савар үгүй болсон

Харанхуй хорт мананг хурдан салхи хөөсөн.

Гурван хоббит өндийж, суниагаад, нүдээ арчсанаа ухасхийн босоцгоов. Тэд Фродо, Том хоёр руу гайхан харж, тэгснээ өөрсдийнхөө хөдөрсөн цагаан өнгөтэй бохир даавуу, алтан чимэглэл рүү харснаа бүр ч мэл гайхан яах учраа олохгүй зогсов.

- Энэ чинь одоо юу гээч болох нь энэ вэ? – гэж Мерри хазгай тавьсан алтан титэмтэй толгойгоо сэгсрэн байж асууснаа гэнэт дуугүй болж, нүдээ анив:

- А-а, саналаа саналаа, шөнө бидэн рүү хойд зүгээс дайрсан, тэд тоолшгүй олон байсан. Зүрхийг минь нэвт жадалсан – гэснээ цээжээ барьж үзээд – яг л зүүдэлж байгаа юм шиг! Чи хаашаа алга болчихсон бэ? Фродо?

- Төөрчихсөн байх аа, гэвч одоо тэр тухай яриад яах вэ, болоод өнгөрсөн. Одоо замдаа гаръя!

- Юуны чинь замд гарах, би шалдан явах юм уу? – гээд титэм, бүс, бөгжөө тайлан шидэлж, үхдэлийн нөмрөгийг тасдаж хаяад өөрийнхөө хүрэм, өмд, цувыг хайж байгаа аятай өвсөн дээгүүр нүдээрээ тэмтрэв.

- Хувцсаа хайсны хэрэггүй, тэртэй тэргүй олохгүй –гээд Том хоромхон зуурт Булшны толгойноос бууж, юу ч болоогүй юм шиг тэднийг тойрон бүжиглэв.

- Яагаад хайх хэрэггүй гэж? Тэгээд яах юм бэ? – гэж Пин бүжиглэж буй Томыг гайхан харав.

Том зөвхөн толгой сэгсрэв.

- Буцаж гардаггүй гүнээс гэрэлт ертөнцөд амьд гарч ирсэндээ баярла, булшны харанхуй нүхэнд аймшигт үхдэл сүгнүүдийн савраас аврагдах найдвар байдаггүй юм. Булшны ялзарсан хогнуудаа тайлж хаяад өвсөн дээгүүр нүцгэн алх, хурдал! Булшны тоосоо гөвөх хэрэгтэй! ... Харин би анд явлаа.

Тэгээд исгэрч, дуулсаар уул өөд гүйлээ. Фродо түүний араас удаан харж зогслоо. Том өмнө зүг, толгодын дундах ногоон хонхроор исгэрч, дуулан хол хол харайн одов:

Хоп-топ, Хоп-хлоп, Чи хаана явна, морь минь?

Хоп-хлоп, Хоп-топ, Хүрээд ир, хурдан минь!

Үнэрч хамар, гавшгай сүүл, сонор чихт Хопкин

Үнэнч нөхөр, цагаан хөлт Хопкин-Бобкин

Том Бомбадил ийнхүү дуулсаар, гүйдэл дундаа малгайгаа дээш шидэн нисэлтэн дунд нь барьж авсаар хонхорт далд орсон ба өмнөөс салхилах хүртэл “Хоп-топ, Хоп-хлоп...,” дуу нь сонсогдсоор байв.

Өчигдрийнх шиг халуун байлаа. Хоббитууд тушаал ёсоор өвсөн дээгүүр баахан гүйв. Дараа нь өвсөн дээр тарвалзан наранд ээж, цэвдэг хүйтнээс дулаан газарт ид шидээр гарч ирсэндээ туйлгүй баярлан байв. Үхлийн аюулт өвчинд нэрвэгдсэн хүн нэг удаа орноос хөнгөхөн босч, амьдрал дахиад өмнө нь цэлийтэл нээгдсэнийг харахдаа ингэж баярладаг билээ.

Томыг эргэж ирэхэд тэд усан хулгана болтлоо хөлөрч, бас хангалттай өлсч амжсан байлаа. Толгойн ирмэг дээгүүр түүний шидсэн малгай үзэгдээд дараа нь өөрөө, тэгээд зургаан морь, тав нь тэдний пони, нэг нь түүнийх, бодвол Хопкин-Бобкин байх, бие өндөр, бахим чийрэг, тарган морь байв. Урьд нь хуучин эзэн Мерри морьдыг санаандаа орсон үгээр нэрлэдэг байсан бол одоо Том тэдэнд нэг нэг нэр өгсөн тул тэр нэрээр нь дуудах болов. Том морьдыг нэг нэгээр нь дуудахад морьд цувран ирж жагсав. Том хоббитуудад хөгжилтэйхэн мэхийн ёсоллоо.

- Морьдоо авцгаа! Хөөрхий тэд айсандаа эздээ хаяад зугтсан байна. Адуу их сонор амьтан, үхдэлийн үнэр авангуугаа л байдаг хурдаараа зугтаасан. ... Гэхдээ эднийг буруутгаж болохгүй. Өөрөө булш руу яваад орчихдог амьтан харсан уу? Хоббитууд морьдоосоо суралцах хэрэгтэй юм биш үү? Ачаа нь бүрэн бүтэн байгааг хараач гэм хөөе! сайн байна, бяцхан морьд минь! Мэдрэмж нь зөв байна. Аймшигт үхдэл сүг, газар дорх үхлээс зугтаасан байна. Эднийг буруутгаж болохгүй ээ!

- Зургаа дахь нь хэний морь вэ?

- Минийх ээ, миний найз байгаа юм. Дуртай газраа идээшилж явдаг, дуудсан цагт давхиад ирдэг юм. Том хоббитуудыг хамгийн дөт замаар газарчилж өнөөдрийн дотор Их Замд хүргэнэ.

Хоббитууд баярлаж талархсан гэж тоймгүй, харин Том инээж:

- Гэрт Алтангаа хүлээж байгаа, ажил амаар дүүрэн. Түүний санааг зовоохгүйн тулд Том хоббитуудыг хүргэж өгч байгаа юм. Тэд бөөн ажил ундруулна! Хөгшин нарснаас сугалаад гаргамагц булшинд яваад орчихно. Их зам хүргэхгүй бол маргааш юу болох вэ? Үгүй ээ, хүргэж өгөөд салсан нь дээр.

Нарны байдлаас харахад арван цаг ч болоогүй байсан боловч хоббитууд хоол хүрэлцээтэй

байсан бол сайхан үдийн зоог барих байлаа. Нөөц зөвхөн өглөөний хоолонд хүрэлцэж байсан тул өөрсдөдөө үлдсэнийг Томын авчирсантай нийлүүлээд бүгдийг хамж идэв. Тэднийг хооллож байх хойгуур Том толгой дээгүүр явж, тарааж хаясан эрдэнэсийг цуглуулав. Ихэнхийг нь нэг дор овоолоод “Хэн үүнийг олно, шувуу ч бай, араатан ч бай, хүн ч бай, эльф ч бай тайван эзэмш” гэсэн пайз босгов. Үхдэлүүдийг дахин ирүүлэхгүйн тулд булшны хараалыг ингэж задалжээ. Эрвээхэйн далавч адил өнгө солонгорсон индранил эрдэнийн зүүлтийг өөрөө авлаа. Том түүнийг ямар нэг юм санаж ядан удаан гэгч харсны эцэст толгой сэгсрэн “Тэр минь нэгэн цагт үүнийг зүүж байсан шүү дээ, өдрөөс гэрэлт царайтай, индранилаас илүү туяатай байсан даа... Алтангаа минь энэ зүүлтийг зүүт, бид хоёрт өнгөрснийг дурсуулах амьд од болог” гэж ганцаараа ярив.

Хоббит бүрт улаан шаргал өнгийн мушгиа хээтэй урт, шулуун чилүүр хутга өгөв. Ир нь хүйтэн, хатуу өнгөөр гялалзаж, хуй нь хөнгөн, бат бэх үл мэдэх төмөрлөгөөр хийж, од мэт гялалзах эрдэнийн чулууны хэлтэрхийнүүд шигтгэсэн байв. Гайхамшигтай хуй нь хамгаалсан юм уу, булшны шившлэг хамгаалсан юм уу, өчүүхэн ч зэв тогтоогүй, сэв гараагүй байлаа.

- Энэ чичлүүрүүд багачуудад илд шиг хэрэг болно. Галт ууланд хаа сайгүй нуугдаж байдаг Хар эзний хөнөөлт зарц нар шөнийн цагаар нэг биш удаа дайрна биз. Гэвч гэнэдүүлэн дайрч болохгүй. Арнорын чичлүүртэй хоббит бол нууц хатгууртай туулай гэсэн үг. Дайрах л юм бол хатгана... Дайрахгүй гэж андгайлах хэрэгтэй.

Энэ чичлүүр хутгануудыг мянга таван зуу гаруй жилийн өмнө Арнорын эзэнт улсын зэвсгийн дархчууд давтаж хийсэн. Тэр улс умардын түрэлтэд унасан, цэргийн хүчээр дийлэгдэхгүй байсан боловч умард Ангмарын хязгаарыг тэр үед илбэчид захирч байсан учир хар шидээр дийлсэн гэж Том тайлбарлав.

- Тэр үеийн үйл явдлуудыг одоо мартацгаасан. Эртний хаадын удам ганц нэг тэнэмэл дайчид л үлдсэн, тэд хэнэггүй омгуудыг хамгаалдаг юм. Тэнэмэл дайчид тун цөөхөн болсон...

Юун тухай яриад байгааг хоббитууд сайн ойлгосонгүй, гэвч тэдний нүдний өмнө гэнэт тоолшгүй олон он жилүүд төгсгөлгүй уудам тал мэт дэлгэгдэж, тэр талаар сүүдэр мэт дүнсгэр, өндөр, урт илд зүүсэн хүмүүс тэнүүчлэн явах бөгөөд сүүлчийнх нь духан дээрээ бүдэг одтой байхыг үзэв. Дараа нь хий үзэгдэл замхарч нарны гэрэл гийгүүлэв. Удаан суух шаардлага байсангүй. Шуудайнуудаа түргэн боогоод /нүцгэн гурав аль хэдийн нөөц хувцсаа өмсчээ/ морьдоо ачаалав. Бэлгийн зэвсэг бүснээс унжиж, хөлд тээглэнэ. “Энэ ч хэрэг болно шүү, юу ч тохиолдоо билээ, гэвч тулалдах, тэхдээ бүр илдээр...” гэж тэд бодож байв.

Замдаа орлоо. Морьдоо хөтөлж толгойгоос буугаад мордож хатируулав. Эргэж харахад толгойн орой дээр алтан овоо нарны гэрэлд гялалзан харагдана. Дараа нь нэг хамар тойрч, Булшны толгод үзэгдэхгүй болов.

Фродо эргэн тойрноо харахад нэг ч чулуун шүд харагдсангүй, төдөлгүй тэд налуу өндөрлөг дээр гарч ирэв. Хопкин-Бобкин хөгжилтэй эзэнтэйгээ заримдаа тэдэнтэй зэрэгцэж, заримдаа түрүүлж хатирах бөгөөд тарган том морь хөнгөнөөс хөнгөхөн хатирч байлаа. Том зогсоо зайгүй дуулах боловч огт ойлгомжгүй, эртний хачин хэлээр дуулах бөгөөд дуунд нь зөвхөн ертөнцийг нээснийг гайхаж, биширсэн магтаал байх шиг санагдана.

Бодсоноос хол явах бололтой. Өчигдөр тэд хуурдаг чулууны дэргэд унтахгүй байсан ч зорьсон газраа оройдоо хүрэхгүй байжээ. Толгой дээрээс харагдаж байсан бараан зурвас нь их зам биш, эртний нэгэн эзэнт улсын хилийн зурвас - шуудуу дагасан бут байсан бөгөөд Том энэ тухай ярихдаа нэг зүйлийг дурсан санаж, тэр тухайгаа ярих дургүй байгаа нь илт байв. Шуудууны нөгөө талаар урт ханан хэрэм байв.

Хананд гарсан нүхээр нэвт гарсан жимээр тэд цаад талд нь гараад өргөн хөндийгөөр хатируулав. Цаг орчмын дараа нүд хүрэх газарт хүртэл хов хоосон Их зам харагдав.

- Эцсийн эцэст ирлээ дээ. Миний сонгосон дөт замаар бид хоёр өдрөөс илүү саатсангүй. Магадгүй саатсан нь маань онож, тэднийг будлиулсан байж ч болно – гэж Фродо хэлэв.

Гурван аянч түүнийг гайхан харав. Тэгээд хар морьтнууд болон хагас мартагдаж байгаа айдсаа зэрэг саналаа. Тэд жаргаж буй нар, Их замыг харав. Юу ч байхгүй, хов хоосон.

- Одоо ч гэсэн, өнөө орой ч гэсэн бидний араас хөөхгүй гэж чи бодож байна уу? – хэмээн Пин асуув.

- Үгүй ээ, маргааш ч үгүй байх, тэд хаа нэгтээ эргэлдэж байгаа – гэж Том Бомбадил гэнэт Фродогийн өмнөөс хариулаад – гэхдээ би яг сайн мэдэхгүй байна, эндхийн газрыг би мэдэхгүй. Тэгээд ч би тэр харуудыг мэдэхийг хүсэхгүй байна гэв.

Хоббитууд түүнийг цаашаа хамт яваасай гэж маш их хүсч байлаа. Хар морьтнуудыг Том ёстой болгоод өгнө дөө! Одоо тэд Хоббитанд бүдэг бадаг ярьдаг байсан тэр харийн газарт орно. Тэд буцмаар санагдаж, ийм харанхуй хар алсад юугаа хийх гэж гарав аа хэмээн харамсч байлаа. Тэдэнд маш гунигтай, маш их ганцаардаж байгаагаа мэдрэв. Тэд дуугүй зогсч, Том захиа үгээ хэлсний дараа ч салах ёс хийхээ яарахгүй байв.

- Миний та нарт өгөх сүүлчийн зөвлөгөө. Өнөө оройдоо Уулын гэдэг сууринд хүрээрэй. Тэнд эртний нэг мухлаг байгаа, эзэн нь Наркисс гэж бий. Хоосон толгойтой боловч үнэнч хүн. Та нарыг дайсанд бариад өгчихгүй. Байшин нь олон цонхтой, асар том хаяган дээрх дүүхэлзэж буй пони мориор нь олоход амархан. Мухлагт сайн унтаж хоноод өглөө эрт гар. Та нарын зам урт... За одоо зоригтой урагшил, туулайнууд аа! Хувь заяаныхаа өөдөөс замдаа! Гол нь шөнө болохоос өмнө Уулын сууринд хүр!

Тэд түүнээс мухлаг хүртэл хамт явж, салалтын хундага хамтдаа уухыг гуйсан боловч тэр тачигнатал инээж:

Үүрд надад үнэнч газар нутгийн хязгаар энэ,

Үүрд салцгаая эндээс, найзууд минь!

Тэр морио эргүүлж, малгайгаа өргөөд замын далангийн цаагуур орж үүрд алга болов.

- Одоо бид ноён Бомбадилгүй яана даа, хаашаа явах юм бэ, юу болох юм бэ хэн мэдлээ. Хичнээн ч газар явсан ийм хүнтэй учрахгүй... үнэхээр гайхамшигтай ноёнтон. Харин “пони

морь” гэж хэлсэн нь сайн хэрэг, “ногоон луу” гэх мэтийн юм хэлсэн бол яана? Тэр Уулын сууринд нь хэн амьдардаг юм бол ?

- Хоббитууд ч бий, үлэмж биетүүд ч бий. Ерөнхийдөө гэртээ л харилаа гэсэн үг. Брендизайкууд тийшээ очиж байсан, зүгээр л гэж ярьдаг юм – гэж Мерри хэлэв.

Зүгээр ч байж мэдэх л юм, гэвч Хоббитан биш. “Гэртээ байгаа юм шиг” битгий байгаарай даа. Дашрамд хэлэхэд би одоо Торбинс биш, Нахручинс шүү, тогтоож ав – гэж Фродо хэлэв.

Бүрэнхий болж, харанхуй ар өврөөс өтгөрсөөр, ашгүй урд талд суурингийн гэрэл харагдлаа. Будант тэнгэрийг халхалсан эгц өндөр Уулын бэлд том суурин байна. Аянчид дулаан гал, шөнө өнгөрөөх байр олно гэж найдан тийш яарав.

Бүлэг 9

Дүүхэлзэгч Пони морь

Ужлын суурин бол эндхийн гол суурин бөгөөд эндээс холгүй, уулын цаана Ханан, зүүн тийш гүн хонхорт Сам, цөлийн дундах амьдралын арал болсон ойн цоорхойд Арчет суурин байдаг ажээ. Уулын бэлээс хоёроос гурван бээр газарт тариалангийн талбай байдаг учир ой нэлээд цаашаа ажээ.

Энд бор хүрэн үстэй, намхан, хөгжилтэй, эрх дураараа хүмүүс амьдардаг бөгөөд өмнөх үеийн /өнөөгийнх ч гэсэн/ үлэмж биетүүдийг бодвол хоббитууд, гномууд, эльфүүдтэй эвтэй найртай аж төрдөг ажгуу.

Тэдний домгоор бол, тэд энд бусдаас түрүүнд ирсэн бөгөөд балар эрт цагт баруун зүгээс ирж суурьшсан хүмүүсийн шууд удам ажээ. Эртний олон дайн үй олон ард түмнийг сөнөөсөн боловч хаан, вангууд Их далайн чанадаас эргэж ирэхэд уулынхан амьдарч байсан газартаа л амьдарч байсан, одоо ч амьдарч байгаа бөгөөд харин хаан вангууд аль эрт алга болжээ.

Эндхийн хоббитууд нэлээд олон, үр удам нь Брендидиумыг гаталж, Хоббитанд суурьшихаас хамаагүй өмнө, эртийн эрт цагт энд суурьшсан юм гэнэ. Хоббитууд Ханан сууринд дуртай боловч Уулын сууринд ч суурьшсан, ялангуяа уулын хажуугаар, хүмүүсийн сууцны дээд талд оромжоо барьцгаажээ. Үлэмжүүд болон тожгорууд /тэд бие биеэ ингэж нэрлэдэг/ айл хөрш амьдарч, өөр өөрийнхөө ажил үйлийг эрхлэх боловч хэн хэнийгээ өрөөсөн гутал гэж үздэг байв. Манай ертөнцөд өөр хаана ч ийм ер бусын үлгэр жишээ хамтын амьдрал байгаагүй.

Эндхийн үлэмжүүд болон тожгорууд аян замд дуртай биш, ямар ч байлаа гэсэн дөрвөн суурин байгаа юм чинь өөрсдийнх нь мэдээ хангалттай. Хааяа нэг Уулын суурингийн хоббитууд Забрэнд, Дорно тойрог орох боловч зам хол – Брендидиумын гүүрнээс бүтэн өдрийн зайтай, Хоббитанаас ч цөөн зочин ирдэг. Хааяа нэг хөдөлгөөнтэй брендизайк юм уу молтогчин мухлагт нэг өнжөөд явдаг байсан бол одоо бараг үзэгдэхээ больжээ. Уулын сууринд Хоббитан дахь холын садангуудаасаа дугуугүй чинээлэг хоббитууд суудаг байв. Уулын суурин, Хоббитан хоёрын хоорондын зам дардан байсан тэр үеийг хараахан мартаагүй л байв. Олон брендизайк Уулын суурингаас гаралтай байлаа.

Уулын сууринд хүмүүсийн чулуун байшин хэдэн зуугаараа байсан, голдуу их замын хэлтгийд баруун тийш харсан цонхтой баригджээ. Уулын энэ талаас нуман хэлбэртэй гүн шуудуу ороож, цаагуур нь найдвартай хашаа барьжээ. Их замыг гүн шуудуу огтолж, бат бэх хаалгануудад тулна. Суурингийн өмнө захаас их зам бас л ийм бат бэх хаалгануудаас цааш үргэлжилнэ. Орой болоход тэр хаалгануудыг бөх бат түгждэг ба цаана нь бас харуулын шовгор байна.

Суурингийн дундуур зам баруун тийш, уулын хормой руу эргэж том уушны мухлагт хүргэнэ. Тэр мухлаг маш эрт цагт, энэ замыг хоосон байхад баригджээ. Уулын суурин эртний замын уулзвар дээр баригдсан ба суурингийн баруун талаас аль эртний нэг зам их замыг огтолдог, дээр үед энэ замаар хүмүүс төдийгүй, элдэв амьтад явдаг байжээ. Энэ мухлагт зүг зүгээс

ирэгсэд мэдээлэл солилцдог, түүнийг нь хоббитууд сонсдог байсан цагаас хойш Дорно тойрогт “Ийм мэдээг Уулын сууринд ч сонсохгүй” гэдэг үг гарчээ. Харин хойд зах нь аль эрт эзгүйрч, хойд зам өвсөн дор далд орсон ба суурингийнхан түүнийг “Далд зам” гэж нэрлэдэг байлаа.

Мухлаг байсан хэвэндээ байж, эзэн нь чухал хүн хэвээрээ байв. Энд дөрвөн суурингийн янз бүрийн зэрэг дэвийн залхуучууд, чалчигчид, хов зөөгчид цугларч, тэнүүлчид хоног төөрүүлж, аянчид болон бараг бүх гном буудаг байв. Гномууд Их замаар нааш цааш үргэлж явдаг билээ.

Фродо дагуулуудтайгаа од түгэх цагаар далд замыг өнгөрч, түгжээтэй баруун хаалганд тулахад бүр харанхуй болсон байв. Хаалганы цаадах манааны шовгорт байсан хүн учиргүй гайхсан бололтой босон харайж, дэнлүүгээ барин тэдний өөдөөс дөхөв:

- Хэн бэ? Хаанаас явж байна?

- Танай эндхийн мухлагт буух гэсэн юм. Зүүн зүг явж байна, харин одоохондоо энд ирээд байна даа.

- Хоббитууд! Дөрвийн дөрвөн хоббит! Аялагыг нь сонсоход Хоббитанаас яваа юм байна. Мөн хачин аа! - гэж манаач бувгнав.

Тэгээд хаалгаа яаралгүй нээж, аянчдыг оруулав.

- Манайд Хоббитанаас шөнийн цагаар зочин ирэх нь ховор. Өршөөгөөрэй, Яагаад та нар зүүн зүг, Уулын суурингаас ч цаашаа явах хэрэг гараа вэ? Та нарыг хэн гэж дуудах вэ? Сониучирхлаа гэхгүй биз дээ?

Биднийг янз янзаар л дууддаг, бидэнд янз бүрийн л ажил хэрэг гардаг, энэ тухай ярьдаг газар биш – гэж Фродо түс тас хэлэв. Хэтэрхий сониуч манаач түүнд таалагдсангүй.

- Шөнийн цагаар хэнийг оруулав? гэж надаас асууна шүү дээ!

- Бид Забрэндигээс ирсэн хоббитууд. Бид тус тусдаа өөр өөр ажилтай. Энд хүрээд л ирлээ. Жишээ нь би Брендизайк. Өөр асуух юу байна? Уулын суурингийнхан зочдыг дандаа баяртай, найрсаг угтдаг гэж бидэнд хэлсэн юмсан – гэж Мерри хэлэв.

- Баяртай байлгүй яахав, баярлалгүй яахав. Би юу ч биш ээ, та нарыг сайн шалгаагаад өгнө. Хөгшин Горри сониучирхлаа гэнэ шүү... одоо цагт манайд ирэхгүй амьтан гэж алга. “Пони”-д ороод өөрсдөө гайхах вий.

Манаач тэдэнд сайхан нойрсохыг ерөөж, тэд толгой дохиод цааш явахад тэр дэнлүүгээ өргөн хойноос нь харж байхыг Фродо анзаарав. Хаалга чихран хаагдлаа. Хаалгаа түгжиж байгаа нь сайн хэрэг. Яагаад энэ хаалгачид Хоббитаны хоббитууд сонин байгаа юм бол? Гэндальф биднийг асуусан юм болов уу? Биднийг Ой, Булшинд будилж байх хооронд тэр энд хүрээд ирчихэд гайхах юмгүй. .. гэхдээ л манаач нэг л сэжигтэй харж, нэг л таагүй яриад байсан даа.

Манаач тэдний араас харж харж шовгортоо оров. Гэвч түүнийг хаалга руу нуруугаа

харуулахтай зэрэг хэн нэгэн хаалга давж, харанхуйд уусан алга болов.

Хоббитууд гудамжаар ер бусын том байшингуудыг гайхан харж явлаа. Сэм гурван давхар, олон цонхтой уушны мухлагийн байшинг хараад зүрх нь зогсчих шиг санагдав. Модноос өнөөдөр аварга биетүүд болон бусад хачирхалтай зүйлс ямай, дараа нэг бодъё, гэтэл энд эргэн тойрон үлэмж биет - хүмүүс, тэдний аварга байшингууд – арай хэтэрнэ ээ, өнөөдөржингөө тэвчлээ. Аягүй бол мухлагийн хашаан дотор эмээлтэй хар морьд зогсч, хар эзэд нь цонхоор биднийг харж байгаа ч юм уу?

- Энд буух гэж үү эзэнтээн? Зүгээр л хоббитуудыг хайсан нь дээр юм биш үү?

- Мухлаг чамд юу нь муу байгаа юм бэ? Том Бомбадил биднийг энд буу гэсэн шүү дээ. Байшин дотор тухтай байлгүй дээ.

Мухлагийг гаднаас нь харвал их л тохилог бололтой. Яг Их замын дэргэд, хоёр жигүүр нь уулын хажууд тулсан тул ар талын хоёрдугаар давхрын цонх нь газартай нэг түвшинд байв. Хашаанд өргөн хаалгаар орж, байшинд зүүн талаас нь, зургаан өндөр гишгүүрээр ордог ажээ. Хаалгыг “ДҮҮХЭЛЗЭГЧ ПОНИ МОРЬ”, ЭЗЭМШИГЧ ЛАВР НАРКИСС гэсэн бардам хаяг чимж байв.

Нэгдүгээр давхрын олон цонх зузаан хөшигний цаанаас үл мэдэг гэрэлтэнэ.

Тэд хашаан дотор морьдоо эмээлтэй нь орхиод довжоогоор өгсч, Фродо түрүүлэн орохдоо цагаан хормогчтой халзан, бүдүүн эртэй мөргөлдчих шахав. Тэр нэг хаалганаас нөгөө рүү хөөс дэвэрсэн гүрүүшигтэй пиво өрсөн тавиур барин хурдалж байжээ.

- Танаас юм асуу... - гэж Фродог хэлэх завдалгүй:

- Гялс, би гялс! – гэж тэр мөрөн дээгүүрээ давуулан хашгираад тамхины утаа, хүмүүсийн дүнгэнээн рүү гүйж оров.

Фродог нүдээ ч цавчиж амжаагүй байхад тэр үнэхээр өмнө нь зогсч байлаа.

- Оройн мэнд бяцхан ноёнтоон! Танд юу хэрэгтэй вэ?

- Дөрвөн ор дэр, таван понийн зогсоол. Та ноён Наркисс уу?

- Яг тийм – гэж бүдүүн баярлан хэлээд – намайг Лавр гэдэг. Лавр Наркисс танд үйлчлэхэд бэлэн байна. Хоббитанаас явна уу? – гээд тэр гэнэт нэг юм санах гэсэн бололтой дух руугаа алгадаад – Аа тийм хоббит шүү дээ!, хоббитууд! – хэмээн дуу алдсанаа – Алдар нэрээ хэлнэ үү гэв.

- Ноён Молтогчин, ноён Брендизайк, энэ бол Сэм Скромби, би өөрөө Накручинс.

- Чи ер нь юу хийх хүн бэ?- гэж Лавр Наркисс хуруугаа инчдэн хашгираад – Мартчих юм аа, тэгээд л гүйцээ. Зүгээр зүгээр, санана гайгүй. Би энд бүр яах учраа олохоо байчихаад байна. Та нарын тухайд, за ингэнэ ээ. Хоббитаны хүндэт зочид манайд ховор морилдог юм,

зохицуулалгүй яахав, зохицуулна. Үнэнийг хэлэхэд манайд өнөөдөр бүх өрөө дүүрэн, сул ор байхгүй, алим ч унах зай алга. Манай эндхийнхний үгээр хаалгаар эргэх зай алга – гээд тэр – хөөе, Ноб! Аа муу золигийн үсэн тавхай хожуул аа! гэж хашгирав.

- Очлоо эзээн! Би энд байна! – гээд нэг хаалганаас сэргэлэн байрын төгрөг нүүртэй хоббит үсрэн гарч ирснээ удам нэгтнүүдээ хараад амаа ангайв.

- Боб хаана байна? мэдэхгүй гэнэ ээ!- гэж мухлагийн эзэн хашгираад – тэгвэл олоод ир! Хурдал! Та нарыг манах миний ажил биш, би ар шилэндээ нүдгүй! Хашаанд таван пони байгаа, өөрөө мэдээд зохицуул гэж Бобод хэл!

Ноб зальтай инээвхийлж, нүдээ ирэмчихээд гүйж одов.

- За тэгэхээр, би юу ярьж байлаа- гээд эзэн духаа алгадаад – Ой той гэж жаран хагархай, нөхөх зав байдаггүй. Өчигдөр ч ялгаагүй, амьсгаа авах ч завгүй байсан, бүр толгой эргэчихлээ. Өнгөрсөн шөнө өмнөдөөс энд нэг хачин юмнууд ирсэн. Далд замаар. Дараа нь гномууд, мэдээж хэрэг баруун зүг. Одоо та нар. Хэрэв хоббитууд биш байсан бол яах ч арга алга, зай байхгүй, алья гэсэн ч байхгүй! нэгэнт та нар хоббитууд учир шууд хэлье. Зай байгаа! Анх энэ мухлагийг барьж байхдаа хоббитууд гэнэт хүрээд ирж магадгүй гэж бодоод хойд жигүүрт нэг өрөө нэмж гаргасан юм! Тэнд эндхээс арай нам дор, цонх нь дугариг, тааз нь намхан. Оройн хоол мэдээж аяндаа бүтнэ, одоохон. Явцгаая!

Тэр налуу коридороор дагуулж яваад нэг хаалга нээв.

- Сайхан өрөө дөө! ямар вэ, болно биз? За би гүйлээ, үг ч солих зав алга. Хоёр гартай, хоёр хөлтэй, зургаа байсан ч хүрэлцэхгүй, хонх дараарай, Ноб бүгдийг гүйцэтгэнэ, бүгдийг авчирна. Сонсохгүй байвал, муу хожуулыг, дахин хонхдоод, дэвслээд, хашгираад байгаарай!

Тэр гүйн одож, хоббитуудад амьсгаа авах чөлөө олгов. Тэр үнэхээр ажил ихтэй байгаа нь илэрхий, гэвч хажуугаар нь чалчдаг зантай ажээ.

Тэд өрөөгөө тойруулан харвал, жижигхэн мөртөө маш тохилог харагдав. Задгай зууханд гал улалзаж, өмнө нь намхан буйдан сандлууд байна. Дугариг ширээг шинэ бүтээлгээр бүтээж, дээр нь хонх тавьжээ. Гэвч хонхдох хэрэг гарсангүй, Ноб өөрөө хүрээд ирэв. Нэг гартаа лааны тавиур нөгөө гартаа тавагнууд өрсөн тавиур барьжээ.

Нүд ирмэх зуурт оройн хоол болох халуун шөл, чанасан мах, жимсний чанамал, шинэ барьсан талх, зөндөө их цөцгийн тос, том бяслаг өрлөө. Хоббитанд байдгаас дугах юмгүй, дөнгөж чанасан пиво авчрахад Сэм эргэн тойрноо сэжигтэйеэ харахаа болив.

Эзэн амжиж ирээд, ширээ тойрон алхсанаа уучлал гуйн мэхийв:

- Оройн хоолны дараа хууч хөөрөх хүн хэрэгтэй байж ч магадгүй, үгүй ч байж магадгүй, шууд орондоо ороод сайхан нойрсоорой ч байж болно. Гэвч, хэрэв хүсвэл танхимд очоорой. Бүгд та нарт баярлах болно. Хоббитанаас зочид ирсэн, шинэ мэдээ дуулгах нь мэдээж. Ярьсан ч болно, дуулсан ч болно. Аль нь ч сайхан байх болно! Нэг үгээр хэлэхэд хүсвэл очоорой,

хүсээгүй бол дураараа л бол. Ямар нэг юм хэрэг болбол хонхдоорой.

Цаг гаруй хугацаанд хоббитууд цадталаа идэж, ханатлаа ууж, сэтгэл сэргэв. Фродо, Пин, бас Сэм гурав энд цугласан ардуудыг харахаар шийдэж Мерри үлдэв. Бүх мухлагийн танхим адилхан, бөөн удаа, бөөн шуугианаас өөр юм байхгүй гэж тэр хэлээд татгалзлаа.

- Тэгснээс галын дэргэд тайван сууя. Дараа нь салхинд гарч ч магадгүй. Харин та нар хэлээ сайн хазаарай, бид нууц оргодлууд гэдгээ битгий мартчихаарай, Хоббитан хажууд байгаа, биднийг үнэрлэх л юм бол ямар ч нохой танина шүү!

- За за! өөрөө битгий алга болчихоорой, гадаа сайн, дотор онцсайн гэдгийг санаарай – гэж Пин хариу сургамжлав.

Танхимд есөн жорын ардууд цуглажээ. Фродо нүдээ танхимын гэрэлд дасгаж байгаад тэднийг ажиглалаа. Асар том задгай зуух улаавгар туяа татуулж, гурван том тавиуртай олон лааны гэрэл тамхины утаанд живжээ. Лавр Наркисс галын дэргэд зогсоод хоёр гном болон гурван хачин төрхтэй хүнтэй зэрэг ярилцаж байна. Урт сандлууд дээр суурингийнхан, нутгийн хоббитууд, гномууд, өөр эсэн бусын амьтад холилдон суусан байх бөгөөд утаан дотор сайн ялгаж харах аргагүй байв.

Хоббитаны гурван хоббитыг хараад сууриныхан алга ташиж, баяртай дүнгэнэлдэв. Харийнхан, ялангуяа далд замаар орж ирэгсэд мань гурвыг хөлөөс нь толгой хүртэл ажиглаж байв. Эзэн шинээр ирэгсдийг танилцуулах гэж байж ядан байсан бөгөөд суурингийнхны нэр хоббитуудын урмыг хугалав. Ихэнх суурингийнхны нэр овог ургамал ажээ. Бургаас, Зэгс, Улаан харгана, Хусандай гэх мэт. Уулын суурингийнхан ч тэднээс дутахааргүй, хамгийн түгээмэл нэр нь Хөгшин Царс аж. Хар Үнэгнийхэн, Доргиогийнхон, Нэвт Ухагчийнхан, Урт Хөлтийнхөн лав Хоббитанд садан төрөлтэй нь илэрхий. Жинхэнэ Накручинсынхан ч байна. Тэд Фродог лав шинээр төрсөн ах бололтой гэж тэр дор нь ойлголоо.

Эндхийн хоббитуудын найрсаг зан сониуч зантайгаа холилдсон тул Фродо ямар нэг тайлбар хэлэхээс өөр аргагүй болохыг ойлгов. Тэр түүх, газар зүй сонирхдог /огт сонсоогүй хачин үгс байсан ч цөм толгой дохив/, ном бичих гэж байгаа /гайхаж, таг дуугүй хариу барив/, би болон миний найз нар Хоббитаны хилийн чанадад амьдардаг хоббитуудын тухай, ялангуяа зүүн хоббитуудын талаар мэдээлэл цуглуулж байгаа гэж ярилаа. Бүгд ам амандаа шуугилдав. Хэрэв Фродо үнэхээр ном бичих гэж байгаа, дээр нь хэдэн зуун чихтэй байсан бол хэдхэн минутын дотор хэдэн арван бүлгийн материал авах байлаа. Тэр ч байтугай түүнд тэрэнтэй ч уулз, энэнтэй ч уулз хэмээн зөвлөж, “ядаж энэ Наркиссаас эхэл” гэж зөвлөцгөөв. Фродо яг одоо юу ч бичихгүй гэдгийг ойлгосныхоо дараа тэд Хоббитаны ажил амьдралын талаар шалгааж гарав.

Фродо урьдын адил цагт нэг цайны халбага үг шүүн гаргаж байсан тул төдөлгүй ганцаардаж, буланд суугаад бусдын яриаг сонсов.

Хүмүүс болон гномууд Дорнодод болж буй үйл явдлын талаар мэдээлэл солилцож байх бөгөөд ерөнхийдөө хэн бүхний мэдэх үйл явдлууд аж. Далд замаар орж ирсэн хүмүүсийн газар нутагт хөл дорх газар нь шатаж, тэд шинэ газар хайж байгаа гэнэ. Уулын суурингийнхан

тэднийг өрөвдөж байгаа боловч энэ эрэл манай газрын гадуур өнгөрнө гэж найдаж байна. Ирэгсдийн нэг, хялар нүдтэй муухай царайтай эр мөдхөн зүүн өмнөдөөс довтолгоон болно гэж байна.

- Тэдэнд эртнээс газар бэлдэж байхгүй бол тэд өөрсдөө олоод авна. Зарим нь биш, бүгдээрээ л амьдрах хэрэгтэй шүү дээ – гэж тэр зориуд чанга хэлсэн тул орон нутгийнхан түгшүүртэй харц солилцов.

Хоббитууд тусдаа ярилцаж байна, тэдэнд хүмүүсийн асуудал тийм ч сонин биш. Хоббитуудын нүх, байшин ч Их ард түмэнд сонин биш. Бүгд Сэм, Пин хоёрыг тойрон бөөгнөрөөд цаад хоёр нь гургалдай мэт донгодож байна. Ялангуяа Пиний хэлсэн бүхний дараа инээдийн дэлбэрэлт болж байв. Сүүлийн бөгөөд хамгийн инээдэмтэй мэдээ нь Газар ухагчдын хотхонд зөвлөлийн нүхний дээвэр нурахад зөвлөлийн тэргүүн Вил Дэвслээч чиний идэж байгаа пончикийг сахарын нунтагт хөрвүүлсэн шиг хөлөөсөө толгойгоо хүртэл шохойнд будагдсан байжээ. Инээдэм инээдмээрээ боловч зарим асуулт Фродод тун ч таалагдсангүй. Жишээ нь Хоббитанд нэг хоёр очсон эндхийн нэг хоббит Накручинсынхан хаана амьдардаг, хэн хэнтэй садан төрөл вэ гэж асуув.

Гэнэт Фродо эндхийнхний хэмжүүрээр ч хачин, ширүүн дүртэй, нар салхинд харласан царайтай нэг хүн бүдэг гэрэлтэй буланд гүрүүшиг пиво барин суугаад хоббитуудын хэнэггүй чалчихыг анхааралтай сонсч байгааг анзаарав. Тэр ширээн доогуур ихийг үзэж, нэл шавар болсон анчны гуталтай хөлөө ядрангуй жийгээд, урт гаансаар тамхи сорно. Бүгчим халуунд тэр толботой хар ногоон цуваа тайлсангүй, ядаж юүдэнгээ ч буулгаагүй байв. Юүдэн дороос нүд нь ширүүн гялалзаж байх бөгөөд хоббитууд руу харж байгаа нь илт байлаа.

- Энэ хэн бэ? Танилцуулаагүй шиг санагдаж байна?– гэж Фродо эзэнтэй шивнэлдэх боломж гаргангаа асуув.

- Энэ үү? – гээд эзэн эргэж харалгүй нүднийхээ булангаар түүнийг харангаа – Юу гэх юм бэ дээ, ойлгомжгүй ардууд, нааш цааш хэрж тэнээд л...бид тэднийг шоолж Мөрдөгч гэж нэрлэдэг юм. Тэр амнаасаа үг унагах нь ховор, уг нь ярих юм түүнд бий л дээ. Нэг хоёр сар алга болсноо нэг харахад л ороод ирчихсэн пиво ууж суудаг. Өнгөрсөн хавар энд хэд хэд ирсэн, тэгснээ удтал алга болчихсон, одоо хүрээд л ирсэн байна. Нэрийг нь хэн гэдгийг мэдэхгүй, манайхан тэнэмэл гэдэг юм. Та түүнийг асууж байдаг, хачин юм даа – гэтэл Лаврыг хаа нэгтээ пиво дууссан шалтгаанаар дуудсан тул түүний сүүлчийн өгүүлбэр тайлбаргүй үлдэв.

Тэнэмэл өөрийнх нь тухай ярьж байгааг мэдсэн бололтой яг урдаас нь ширтэж байгааг Фродо анзаарав. Дараа нь Тэнэмэл толгой дохиод, Фродог гараараа даллан урив. Фродо явж очиход тэр юүдэнгээ буулгалаа. Өтгөн хар үс нь бууралтаж эхэлсэн, шанаархаг гонзгой нүүрэнд нь ширүүн харцтай бор нүд зохижээ.

- Намайг Тэнэмэл гэдэг, хэрэв Лавр андуураагүй бол та ноён Накручинс уу?

- Тэр андуураагүй ээ –гэж Фродо хүйтнээр хариулав. Дэндүү анхааралтай хараад байгаа нь огт таалагдсангүй.

- Тийм юм шиг байна, ингэхээр ноён Накручинс, би таны оронд байсан бол залуу найзуудыгаа жаахан аядуу болгох байсан. Дулаацаж, пиво ууж, хоол идэж, хууч хөөрөх мэдээж сайхан л даа, гэхдээ энд та нар Хоббитандаа байгаа биш, тэдний чалчихыг сонсч байхыг хэн байг гэхэв. Энэ миний асуудал биш нь мэдээж – гэж тэр Фродогоос нүд салгалгүй завьжаараа инээмсэглээд – гэвч өнөөдөр Уулын сууринд есөн жорын ардууд цугларсан байна – гэлээ.

Фродо түүний нэвт шувт харцыг дааж гараад юм хэлсэнгүй. Харц одоо Пин рүү чиглэжээ. Пин Найрын тухай ярьж бүгдийн инээдийг барж байгаа харагдана. Дахиад жаахан хүлээвэл Бильбо алга болсон тухай ярина. Үлгэрийн домогт Тробинсын тухай яриа хэн бүхэнд сонин, заримд нь онцгой сонин байх вий.

Фродогийн уур хүрэв. Эндхийн хоббитууд юу ч мэдэхгүй, нэг инээж аваад л мартчихна, Мөрөн голын цаана юу эс болдог билээ. Гэвч хоёр чихээ тавиад чагнаж байгаа, Бильбогийн тухай бага сага юм мэддэг этгээдүүд ч /Лавр Наркисс гэх мэт/ бий шүү дээ.

Фродо яахаа бодож уруулаа зуун суув. Пин сонсогчдынхоо таалалд нийцүүлээд юу ярьж байгаагаа ч мартчихсан бололтой. Бөгжний тухай л бүү яриасай, тэгвэл...

- Даруйхан зогсоо! - гэж Тэнэмэл чихэнд нь шивнэв.

Фродо ширээн дээр үсрэн гараад чангаар ярьж эхлэв. Бүгд Пинээс анхаарлаа холдууллаа. Хоббитууд ноён Накручинс пиво уугаад дуу орчихож гэж бодов бололтой. Фродо өөрийгөө арчаагүй амьтнаар мэдэрч, үг хэлэх болохоороо халаасаа ухдаг зангаараа гараа халаасандаа хийтэл бөгж баригдав. Хурдхан зүүгээд алга болох хүсэл Фродог эзэмдлээ. .. Өөрөө хүссэн биш, хэн нэгний тушаалаар бөгжөө зүүх гээд байгаа бололтой. Тэр оволзсон хүслээ дарж, бөгж өөрөө унаад ямар нэг хэрэг тарихаас сэрэмжилсэн мэт чанга аггав. Ямар ч гэсэн бөгж түүнд тушаал өгсөнгүй, өгөх гэж оролдоод бүтсэнгүй. Фродо эхлээд Хоббитанд ярьдгаар “баяр хүргэж үг хэлэв”

- Бид бүгдээрээ танай найрсагаар хүлээн авсанд тань сэтгэл их хөдөлж байна, би энд түр зуур байснаараа Хоббитан, Уулын суурингийн хоорондын уламжлалт харилцааг сэргээн гэдэгтээ найдаж байна – гээд түгдэрч хоолойгоо засав.

Одоо танхим тэр чигээрээ Фродод анхаарлаа хандууллаа.

- Дуу!- гэж нэг хоббит хашгирав.

- Дуу, дуу!– гэж бусад хоббитууд дэмжин хашгиралдаад –ямар нэг шинэ дуу юм уу, хэн ч сонсоогүй хуучны дуу – гэцгээлээ.

Фродо хоромхон зуур сандарсан боловч Бильбогийн дуулдаг байсан нэг инээдэмтэй дууг / өөрөө зохиосон болохоороо тэр дуугаараа их бахархдаг байв/ санав. Одоо тэр дууны зөвхөн ганц нэг бадгийг л дуулдаг, харин бүрэн эх нь энэ байна:

Уулын бэлд уушийн мухлаг байжээ.

Уул нь энд сонин юм алга,

Сонин юм нь юу вэ гэвэл,

Сайхан пиво ууя уу гээд,

Саран дээрээс сарчин буужээ.

Уушийн газарт сарчин оржээ.

Уул нь энд сонин юм алга,

Тэнд байсан нэг нохой

Түүнийг шоолж үхтлээ инээжээ:

Туйлын чухал хэрэг байжээ.

Сарчин пиво захиалжээ.

Сонин юм энд юу ч алга.

Тэнд байсан нэг муур

Тэнхээ мэдэн бишгүүр үлээж

Тэнгэрлэг бүжгийн ая тогложээ.

Гадаа байсан нэг үнээ

Гоёхон хөгжмийн ая дагаж

Ганган бүжиг бүжиглэжээ.

Гэхдээ бүтэн цаг бүжжээ.

Гэвч энэ хачин биш,

Халбагас, хутга, сэрээ,

Хамаг тавагнууд босч,

Хаа сайгүй гүйлдэж,

Хөөцөлдөн тоглосон ч.

Харин энэ чухал биш.

Нөгөө үнээ босч ирээд

Нэн бардам зоригтойгоор

Царс мод руу очиж

Цоройж байгаад мөргөжээ.

Энэ ердөө аймшигтай биш.

Сарчин пивоо уужээ.

Гэвч энэ бол гай биш.

Сандал доогуур унаад

Сарчин унтаад өгчээ.

Сэрэхгүй бөх унтжээ.

Үлээвэр хөгжмөө муур

Үхсэн амьтан ч сэрмээр

Үнэхээр чанга үлээжээ.

Үнэндээ энэ юу ч биш,

Үлээгээд үлээгээд сэрсэнгүй.

Саран дээрээ байгаа юм шиг

Сарчин унтаад л байжээ.

Сайхь эрийг дамжлаад

Сар руу шидэж орхижээ.

Сая л нэг амжжээ.

Муур бишгүүрээ дахиад

Мундаг чанга үлээтэл

Мулт үсрээд дэлбэрчээ.

Муугүй эд байсан юмсан,

Мөнхийн юм байх биш дээ.

Өнөөх үнээ шувуу шиг хөөрч

Өндөр тэнгэрт нисчихжээ.

Саран дээр хүрээд

Сая л буцъя гэтэл

Санахын ч аргагүй болжээ.

Тэр одоо саран дээр байгаа

Тэглээ гээд инээх юм алга.

Хөгжилтэй нэг нохой харин

Хөхөрсөөр байгаад галзуурчихжээ.

Архичин сарчинг хүлээж ядаад

Ажилдаа түүртэж үнэхээр ядраад

Алиман сар тэнгэрээс

Асар хурдан алга болжээ.

Ашгүй тэгтэл нар манджээ.

Хаашаа ч харсан өдөр шиг өдөр

Хачин сайхан цэлмэг тэнгэр

Харин уушийн мухлаг босдоггүй

Хамаг ард унтахаар хэвтжээ.

Харин энэ чинь юу болж байна?!

Удтал нижигнэсэн алга ташилт. Фродо муугүй хоолойтой, дээр нь дуу маш их таалагджээ. Дахиад пиво захиалж, Фродогийн дууг дахиулахыг хүсэцгээв. Фродо дахин нэг гүрүүшиг пиво ууж, дуугаа эхнээс нь дахин дуулав. Танил аятай, үг нь хялбар учир даган дуулцгаалаа. Одоо харин Фродо өөрөө хөөрч байв. Тэр ширээн дээгүүр хэнэг ч үгүй гүйж, “үнээ шувуу шиг хөөрч” гэдэг мөрийг эхлэхдээ өөрөө дээш хөөрөх гээд хэтэрхий өндөрт цовхорсон тул пивоны гүрүүшигтэй тавган дээр бууж хальтраад ширээн дээрээс шалан дээр морилов. Сонсогчид дуу нийлүүлэн байдаг хоолойгоороо хөхрөх гээд амаа ангайснаа ангайсан чигтээ гацчихав. Дуучин алга болчихжээ. Шал цөмрөөд орчихсон юм уу гэтэл цоорхой ч байдаггүй!

Эцэст нь нутгийн хоббитууд амаа хамхиж, бүгдээрээ босоод Лавраас хариу нэхэхээр дуудав. Пин, Сэм хоёрын дэргэд хэн ч үгүй болж, тэр хоёр руу нэг л ёозгүй, дүнсгэр харцгааж байв. Тэр хоёр хөгжилтэй, нөхөрсөг залуус байснаа Уулын сууринд яах гэж ирсэн нь тодорхойгүй тэнэмэл илбэчний гар хөл болж хувирлаа. Нэг хар царайтай нөхөр тэр хоёр руу бүхнийг ойлгож байгаа харцаар нүдээ онийлгон харах нь байж суух аргагүй эвгүй байдалд оруулав. Тэр өмнөдөөс ирсэн хялар нөхөр рүү нүд ирмэж хамт гараад явчихлаа /тэр хоёр бүхэл оройжингоо шивнэлдээд байсныг Сэм харсан байв/. Тэдний араас манаач Горри гарлаа.

Фродо өөрийгөө ертөнцийн бүх хараалаар харааж байв. Алдаагаа яаж засах тухайгаа бодож байгаад харанхуй буланд юу ч болоогүй юм шиг хэнэг ч үгүй сууж байгаа Тэнэмэл рүү ширээн доогуур мөлхлөө. Фродо хана налаад бөгжөө тайллаа. Бөгж яагаад хуруунд нь углагдчихсан нь таагдашгүй оньсого байлаа. Дуулж байхдаа халаасандаа гараа хийсэн, унахдаа гараа татахад бөгж санамсаргүй углагдчихсан юм болов уу? тэгмээргүй дээ... Бөгж өөрөө ийм тоглоом тоглож, өөрийгөө хаана байгааг хэн нэгний хүслээр юм уу, тушаалаар илрүүлж байна уу? гэвч хэний хүсэл, тушаалаар? Саяны гараад явдаг гурав маш их сэжигтэй байлаа.

- За, ийм байдаг байж. Гэвч яах гэж та ингэж байгаа юм бэ? – гэж Тэнэмэл түүн рүү харалгүйгээр хэлээд – тэр залуучууд ч гэсэн үүнээс илүү аюул тарихгүй байсан. Тиймээ, шууд л хөлөө хавханд хийчихлээ. Хөлөө юу? Хуруугаа юу?

- Та юун тухай яриад байгааг ойлгохгүй байна – гэж Фродо зэвүүрхэнгүй хэлэв.

- Ойлгож байгаа, ойлгохын дээдээр ойлгож байгаа – гэж Тэнэмэл жуумалзаад - Энэ шуугиан жаахан намдаг, тэгэхээр та зөвшөөрвөл би тантай ярилцмаар байна ноён Торбинс.

- Бид юун тухай ярих билээ – гэж Фродоо жинхэнэ нэрээ хэлснийг анзаараагүй юм шиг хэлэв.

- Танд ч, надад ч маш чухал зүйлийн тухай – гэж Тэнэмэл хэлээд Фродогийн нүд рүү харж – тэхдээ бүү ай, айх юм байхгүй гэлээ.

- За яахав, сонсьё, жаахан байзняя - гэж Фродоо түүний ярианд автахгүйн тулд хэлэв.

Задгай зуухны дэргэд халуун маргаан өрнөж байна. Гал тогооноос ирсэн Лавр Наркисс ер бусын тохиолдлын тухай хоорондоо зөрөөтэй, ойлгомж муутай яриаг сонсч байна.

- Би өөрийн нүдээр харсан, ноён Наркисс. Яаж харагдахгүй болохыг нь харсан. Зүгээр л агаарт уусчихсан, тэгээд л гүйцээ- гэж нэг хоббит хэлэв.

- Та тэгж хэлж байна уу, ноён Хөгшин Царс! – гэж эзэн яаран анхааруулав.

- Тэгж хэлж байна! – гэж ноён Хөгшин Царс нотлоод – Хэлсэн үгэндээ эзэн болно гэв.

- Үгүй дээ, нэг л биш байна – гэж хөгшин эзэн эргэлзэнгүй толгой сэгсрээд – ноён Накручинс зүгээр л агаарт уусчихлаа гэж үү? Тэгээд ч эндхийн агаар гэж юу билээ!

- Тэгвэл тэр хаана байна?- гэж хэд хэдэн хүн зэрэг хашгирав.

- Би яаж мэдэх юм бэ? Миний хувьд тэр өглөө мөнгөө төлөхөө мартчихгүй л бол болох нь тэр. Хэрэв ноён Молтогчин хаана ч уусчихаагүй зогсч байхад тэр хаашаа алга болдог юм бэ?

- Яаж алга болсныг нь би хоёр нүдээрээ харсан шүү дээ – гэж Хөгшин Царс зөрүүдлэв.

- Ямар нэг алдаа гарчээ – гэж Лавр Наркисс бууж өгөхгүй хэлээд хагарсан сав суулгаа тавиур дээр цуглуулав.

- Мэдээж алдаа гарсан, би хаашаа ч алга болоогүй. Зүгээр л Тэнэмэлтэй хэдэн үг солих гэсэн юм – гэж Фродо хэлээд урагшаа гарч ирэв. Задгай галын гэрэлд ил гарахад хэн ч түүнээс хий үзэгдэл харсан мэт ухарсангүй. Зүгээр л ширээн дороос хурдан мөлхөж гарсан гэж яаж тайлбарлаад нэмэр болсонгүй. Үлдсэн хоббитууд болон Уулын суурингийнхан пиво ч, яриа ч сонирхсонгүй, салхинд хийсэх мэт алга болж, хаалган дээрээс зарим нь Фродо руу урамгүй хараад гарцгаалаа. Зөвхөн гномууд болон алс газрын хоёр гурван хүн түр саатаж эзэнтэй салах ёс хийгээд Фродо болон найз нар руу нь хялайж ч харалгүй гарлаа. Ганцхан Тэнэмэл гэрэлгүй ханын дэргэд хэнд ч анзаарагдалгүй үлдэв.

Уушийн мухлагийн эзэн нэг их санаагаар унасангүй. Энэ ардууд ер бусын үйл явдлыг хэлэлцэхээр дахиад олон оройг энд цугларч өнгөрүүлнэ гэдэгт итгэлтэй байгаа бололтой.

- Та юу хийж байгаа чинь энэ вэ, ноён Накручинс? Байнгын үйлчлүүлэгчдийг маань тараагаад, сав суулгыг минь хагалж байдаг?- гэж хөгжилтэйгээр зэмлэв.

- Ийм их төвөг учруулсандаа уучлал гуйж байна. Та надад итгээрэй! Санаатай ингээгүй юм шүү, тун ч харамсалтай юм боллоо.

- Байдаг л юм, ноён Накручинс! Гэвч хойшдоо алга болмоор ч юм уу өөрөөр илбэдмээр санагдвал эхлээд хэлж байгаарай, тэхдээ хэн нэгэнд биш, надад. Манай эндхийнхэн элдвийн илбэ милбэ, ид шидэнд дасаагүй. Эхлээд ардуудыг бэлтгэх хэрэгтэй.

- Дахиад ийм юм болохгүй ээ, ноён Наркисс. Би хатуу амлаж байна. Ерөнхийдөө амрах цаг боллоо. Бид өглөө эрт хөдөлнө. Манай морьд найм гэхэд бэлэн болсон байвал сайн байна, та хичээгээрэй. Болно биз дээ?

- Болноо, бэлэн болно! Гэвч унтахын тань өмнө тантай биечлэн ярих юм байна. Би зарим нэг чухал юмыг саналаа, таны урмыг огт хугалахгүй гэж найдаж байна. Та зөвшөөрвөл би энээ тэрээ юм шалгачихаад тан дээр очье!

- Тэг л дээ – гэж Фродо сулхан хэлэхдээ унтахын өмнө чухал хэргийн тухай хичнээн цаг ярих бол? Эд нар бүгдээрээ санаа нэгтэй юм биш байгаа?- гэж бодов. Лавр Наркиссын цайлган төгрөг царай ч түүнд сэжигтэй харагдаж байв.

Бүлэг 10

Тэнэмэл

Фродо Пин, Сэм гурав ар араасаа цуварсаар харанхуй өрөөндөө орж ирэв. Мерри алга, задгай зуухны гал дөнгөж цогтой байв. Тэд хэдэн хагалаадас мод хийгээд, цогийг үлээн асаасан хойноо хаалганы дэргэдэх буйдан сандал дээр Тэнэмэл тэднээс хоцролгүй орж ирээд сууж байгааг үзэв.

- Өө! Энэ чинь хэн бэ? Юу хэрэгтэй юм бол? – гэж Пин дуу алдав.

- Намайг Тэнэмэл гэдэг юм. Танай найз надтай ярилцана гэж амласан, мартаагүй байх гэж найдаж байна.

- Тийм ээ, та “тун чухал зүйл” ярина гэсэн, тэр чинь юу билээ?

- Үнэхээр тун чухал. Үнэ хөлсөө эхлээд тохирчихъё.

- Юун үнэ хөлс байдаг билээ?

- Битгий мэдэн будил! Би танд мэдэж байгаа юмаа хэлээд сайн санааны зөвлөгөө өгнө, хариу талархал хүлээж байна.

- Хэр үнэтэй юм бол доо? – гэж Фродоо асуунгаа мөнгө саагчийн хавханд орчихлоо гэж бодоод авч гарсан мөнгөө санаандаа тоолж үзэв. Бага ч байна, өгөхөд ч хайран байна.

- Түрийвчний чинь хэмжээгээр – гээд Тэнэмэл урам муутай мушилзсан нь Фродогийн тооцоог таасан мэт.- зүгээр л та нар намайг дагуулаад яв, би хэрэгтэй цагтаа та нартай хамт явна.

- Бас юу гэнэ ээ! – гэж гайхсан, бас түрүүчийнхээсээ илүү түгшсэн Фродо хэлээд – бидэнд дагуул хэрэггүй, хэрэв хэрэгтэй бол эхлээд судална, хэн юм бэ, юу хийдэг юм бэ? гээд л.

- Тэгэх хэрэгтэй – гээд Тэнэмэл хөлөө ачин тухтай сууж аваад – та одоо ухаан орж байх шиг байна, энэ чинь сайн хэрэг. Тэнэглээд яахав. Би танд мэдэж байгаа юм аа ярья, талархал таных, удаахгүй биз дээ.

- Тэгвэл яриад бай, та юу мэдэж байгаа юм бэ? – гэж Фродо тэвчээр алдав.

- Хэтэрхий их юм мэднэ – гэж Тэнэмэл урьдын адил мушилзан инээвхийлснээ босч “та нарын араас хэн...” гээд хаалга түргэн нээж харснаа удаан түгжив. Тэгээд буйдан сандалд дахин сууж, дуугаа намсган:

- Би их нарийн сонсголтой. Алга болж чадахгүй нь үнэн, гэвч би хамгийн сонор шувууг ч барьж л байлаа. Өнөө орой би баруун хаалганаас хоёр лигийн зайд Их замыг манасан юм. Нэг харсан чинь Нойтон Жалгын замаар дөрвөн хоббит ирж явна. Тэд хоорондоо юу гэж ярьсан,

хөгшин Бомбадилтай яаж салах ёс хийснийг яриад яахав. Гол нь нэг хоббит нөгөөдөө “Би одоо ямар ч Торбинс биш, Накручинс шүү”- гэж байх юм. Тэгээд надад сонирхолтой санагдахаар нь би араас нь дагаад “Дүүхэлзэгч Пони”-д орж ирсэн юм. Ноён Торбинс жинхэнэ нэрээ дэмий нэг нуугаагүй байх, гэвч би түүнд илүү их болгоомжтой бай гэж зөвлөх байна.

- Миний нэрийг энд хэн нэгэн яагаад сонирхоод байгааг би ойлгохгүй байна – гэж Фродо ууртай хариулаад - тэгээд ч яахаараа миний нэрийг та сонирхож байгааг ч ойлгохгүй байна. Ноён Тэнэмэл дэмий нэг чагнаж тагнадаг байх, гэвч би түүнд оньсогоор битгий ярь гэж зөвлөмөөр байна.

- Үг үгээр дүйж байх шив – гэж Тэнэмэл инээгээд – гэхдээ оньсого байхгүй. Би Фродо Торбинс гэдэг нэртэй хоббитыг хүлээж байгаа юм, гэвч надад цаг бага байна. Тэр надад болон миний найз нарт туйлын чухал нууцыг тээн Хоббитанаас гарсныг би мэднэ... гэхэд Фродо ухасхийн босч, Сэм түүнийг өдсөн харцаар хэмжиж байгааг хараад тэр “Кинжаалаа битгий шүүрээрэй” хэмээн анхааруулав. Тэр урагш тонгойж тэднийг эргэлзэнгүй хараад:

- Би та нарын нууцыг та нараас илүү хадгална. Хадгалах хэрэгтэй! Маш болгоомжтой, сүүдэр болгоныг ажиглаж яв! – гэж аяархан боловч хатуу хэлээд – хар морьтнууд уулын сууринд аль хэдийн ирсэн. Нэг нь өчигдөр далд замаар давхиж явсан гэсэн, өнөө орой хоёр дахь нь ирсэн. Нэг нь өмнөдөөс, нөгөө нь хойноос.

Хэсэг чимээгүй сууснаа Фродо наад хоёртоо:

- Би шууд таамаглах ёстой байсан юм. Манаач шалгаагаад л байсан, эзэн хажуугаас хараад л байсан нэг юм дуулсан байж мэднэ, тэр аягүй бол танхим руу зориуд оруулсан байх. Бид ч гэж бид - Өрөөндөө сууж байхын оронд тийшээ орж л байдаг.

- Тэгэх байсан юм – гэж Тэнэмэл батлаад – би та нарт тайлбарлах гэтэл Лавр болиулсан юм. Шуугиан тариад яахав гэж.

- Та түүнийг... гэж Фродо хэлтэл Тэнэмэл асуултыг нь урьдаас ойлгоод:

- Үгүй ээ, би түүнийг тэгж бодохгүй байна. Лавр зүгээр л элдвийн тэнэмлүүд зочдыг нь үймүүлэхэд дургүй байдаг юм.

Фродо түүн рүү санаа зовсон байртай харлаа. Тэнэмэл Фродо руу хараад урьдын адил муухан инээмсэглэн:

- Үнэнийг хэлэхэд би ч гэсэн адгийн тэнүүлчээс юугаараа дээр харагдах билээ? Гэхдээ бид дахиад уулзана гэж найдаж байна, тэгэхээр чи дуугаа дуусгалгүй яах гэж алга болсноо тайлбарлаарай. Энэ үзүүлбэр...

- Тийм ээ, энэ үзүүлбэр зүгээр л санамсаргүй болсон – гэж Фродо үгийг нь таслав.

- Санамсаргүй гэж бодъё. Гэвч чиний энэ санамсаргүй үзүүлбэр чинь та нарыг аюулд унагах

гэж байна. Чи гэсэнд уучлаарай, энэ бол итгэлийн тэмдэг, манайд өөрөөр ярьдаггүй юм.

- Дассанаар л ярь, аюул гэдэг бол шинэ зүйл биш. Морьтнууд биднийг эртнээс хөөж байгаа. Харин ч бид Уулын сууринд саатсан нь зөв боллоо.

- Чи дэмий л тэгж бодож байна даа, тэд эргээд ирнэ, үгүй гэхэд бусад нь ороод ирнэ. Өөр олон байдаг юм. Тэдний тоог би мэднэ – гээд түр дуугүй болсноо нүд нь гялалзаж:

- Энэ Уулын сууринд бусад газартай адил новшийн хогнууд цөөнгүй байдаг юм. Жишээ нь Цохиур Бургас байна. Та нар өнөөдөр хараа биз дээ? Тэр маш муу нэртэй, тэднийд хог новш бүхэн ирдэг. Анзаараа биз дээ? Хар царайтай, муухай инээвхийлдэг. Өмнөдийн гэх юмтай нөхцчихсөн, чиний санамсаргүй үзүүлбэрийн чинь дараа тэрэнтэй цуг гарсан. Өмнөдийнхөн надад нэг л сэжигтэй санагддаг, Цохиур бургас хэнийг ч хамаагүй сохор зоосноос худалдана, сохор зоосоор байтугай зүгээр л хүний мууг үзэх гэж ховлоно.

- Тэр хэнийг худалдах гэж? Миний үзүүлбэр тэрэнд ямар хамаатай юм бэ? – гэж Фродо түүний анхааруулгыг анзаараагүй юм шиг асуув.

- Та нарыг зарна, өндөр үнээр шүү, өнөө оройн тухай хов их үнэ хүрнэ. Хуурамч нэрээр одоо чи хэнийг ч хуурахгүй. Бүх юм тодоос тод байна. Та нарыг өглөө болохоос өмнө танина. Хангалттай тайлбар хэрэгтэй юу? Намайг дагуулаар авна уу, байна уу та нарын хэрэг. Хоббитан, Манант нуруу хоёрын хооронд би хөндлөн гулдгүй хэссэн хүн. Би та нарын бодож байгаагаас хавьгүй ахмад настай, миний туршлага та нарт хэрэг болно. Их замаар явж болохгүй, морьтнууд тэнд өдөр шөнөгүй отолт хийнэ. Уулын суурингаас гарчихаж болох л юм, наранд нэг цаг яваад дараа нь юу болох вэ? Та нарыг замаас зайтай газар нөмрөөд авна. Тусламж дуудах хэн ч үгүй. Та нар руу дайрвал юу хийхээ мэдэж байгаа юм уу? Болгоомжтой л яваарай!

Тэнэмэлийн дуу хоолой өөрчлөгдлөө. Түүний тайван царай барайж, сандлын гар түшлэгийг чанга базаж байгааг хоббитууд харав. Өрөөнд чимээгүй, бүрэнхий, задгай зуухны гал дөнгөж улалзана. Тэнэмэл өнө эртний ямар нэг үйл явдлыг дурсч, харанхуй шөнийг чагнаж байгаа мэт харагдана.

- Тэгэхээр та нарыг мөшгөж байгаа этгээдүүдийг би та нараас илүү мэднэ –гээд тэр алгаараа духаа арчаад – та нар тэднээс айж байна, энэ зөв, харин хамгийн аймшигтай юмыг ойлгохгүй байна. Маргааш гэхэд та нарын мөр алга болсон байх ёстой. Тэнэмэл та нарыг далд замаар хөтөлж явна, хэрэв та нарт газарчин хэрэгтэй бол шүү дээ.

Дахиад нам гүм болж, Фродо айсан, эргэлзсэндээ хариу хэлж чадахгүй суув. Сэм хөмсөг зангидаж, эзэн рүүгээ хяламхийснээ босч ирээд:

- Эзэн минь, таны зөвшөөрлөөр би үгээ хэлье! Тэнэмэл юу гээд байна вэ? болгоомжтой бай! – гэж байна, би үүнийг зөвшөөрч байна. Харин бид эхлээд түүнээс болгоомжлох ёстой юм биш үү? Тэр Бөглүүдийн хүн, тэнд сайн хүмүүс байдаггүй гэж ярьцгаадаг. Тэр бидний тухай залыт аргаар мэдсэн нь илэрхий байна. Тийм учраас үүнийг газарчнаар авах юм уу? тэр биднийг өөрийнх нь хэлснээр тусламж дуудах хэн ч байхгүй газар хөтлөөд орчихвол яах юм бэ? Үгүй

ээ, эзэн минь та юу гэж бодно хамаагүй, харин би түүнд итгэхгүй байна.

Пин юм хэлэх гэсэн бололтой суудал дээрээ займчсанаа дуугүй болов. Тэнэмэл Сэмийн үгэнд хариу хэлсэнгүй, Фродо руу асуусан харц талбилаа. Фродо харцаа буруулав.

- Үгүй ээ Сэм, чи буруу бодож байна – гэж Фродо үгээ зөөж тавин хэлээд тэнэмэлд хандаж - чи харахад тийм хүн биш, тэгсэн мөртөө яагаад зүсээ хувиргаад байгаа юм бэ? Ярьж эхлэх нь Уулын суурингийн хүн шиг байсан, гэтэл одоо дуу хоолой нь өөр болчихлоо. Сэмийн зөв биш үү, чи бидэнд сүүдэр болгоныг хянамгай ажигла гэж зөвлөсөн мөртөө бид чамд эргэлзээгүй шууд итгэхийг хүлээгээд байгаа чинь ямар учиртай юм бэ? Чи яг хэн юм бэ? чи миний тухай, миний ажил хэргийн тухай юу мэдэж байгаа юм бэ? Яаж мэдсэн юм бэ?

- Та нар миний зөвлөгөөтэй, зөвлөгөөгүй болгоомжилж байгааг чинь би харж байна. Гэвч болгоомжлох гэдэг нэг хэрэг, шийдэж чадахгүй байх гэдэг өөр хэрэг. Надгүйгээр та нар Уудам хөндий хүрч чадахгүй, тиймээс хүссэн ч, хүсээгүй ч надад итгэх болно. Гэхдээ би та нараас итгэл гэхээсээ илүү шийдэмгий байхыг хүсч байна. Чиний асуултад бүрэн биш ч гэсэн ажил хэргийн тусын тулд хариулахад бэлэн байна. Гэвч та нар итгэхгүй байхад бэлэн учраас хариулах хэрэг байна уу? Үүр цайх хүртэл ярьж амжих байх. Тэгэхээр ер нь...

Хаалга тогшиж, босгон дээр Наркисс лаа барьчихсан, цаана нь Ноб хувин ус барин зогсч байв. Тэнэмэл хэнд ч анзаарагдалгүй босч харанхуй буланд очиж суув.

- Та нарт сайхан нойрсохыг ерөөхөөр ирлээ – гэж тэр хэлээд, ширээн дээр лааны тавиур тавьж – Ноб, усыг энд биш, унтлагын өрөөнд оруул! – гэж тушаагаад Нобыг гармагц хаалга хаагаад:

- Ийм юм л даа – гэж мухлагийн эзэн санаа зовсон байртай, шийдэмгий бус өгүүлээд – хэрэв надаас болж хохирол учирсан бол уужуу сэтгэл гаргаж уучлаарай. Та нар мэдэж байгаа. Олон ажил дээр дээрээсээ давхцаад, би гэдэг хүн завгүй. Надад Хоббитанаас ирэх Фродо Торбинс гэдэг хүнийг хүлээж авах даалгавар өгсөн юм л даа.

- Тэрэнд чинь би ямар хамаатай юм бэ? – гэж Фродо яаран асуув.

- Өө, нээрэн тийм л дээ! – гэж мухлагийн эзэн толгой дохиод – та зүгээр л анхааралдаа авчих. Тэр хүнийг Накручинс гэдэг нэртэй ирнэ гэж хэлээд, уучлаарай, содон тэмдгийг нь хэлж өгсөн юм.

- Тийм үү? Тэгээд ямар шинж тэмдэгтэй юм бэ? – гэж Фродо хурдхан үгийг нь таслав.

- Ердийн хоббитоос өндөрдүү, зузаан биетэй, улаан хацартай – гэж Лавр цээжээрээ товхийтэл хариулав. Пин хм-хм – хэмээн дуу алдаж, Сэм уруу царайлав.

- “Гэхдээ энэ бол бараг содон тэмдэг биш л дээ. Хоббитууд бүгдээрээ хоорондоо адилхан. Бүгд зузаан биетэй, улаан хацартай. Гэхдээ л бусдаасаа өндөрдүү, улаавтар үстэй, давхар эрүүтэй гэдгийг санаж ав. Нүдээ онилгон бодлогошронгуй хардаг” – гэж надад хэлсэн. Гэхдээ хэрэв тийм биш бол өршөөгөөрэй, би түүний хэлснийг хариуцахгүй.

- Түүний үгийн төлөө гэнэ ээ? Тэр чинь тэгээд хэн юм бэ? – гэж Фродо догдлон асуув.

- Ээ, эцэг минь, би хэлэхээ мартчихаж. Миний найз Гэндалф байхгүй юу. Ер нь бол тэр шидтэн л дээ, гэвч бид хоёр олон жил нөхөрлөж байгаа юм. Харин одоо би түүнээс ямар шийтгэл ирэхийг хэлж ч мэдэхгүй байна. Пиво исгэдэг торх болгох юм уу, эсвэл пин болгож хувиргах юм уу бүү мэд, тэр шийтгэхдээ хурдан. Дараа нь харамсч магадгүй л дээ, гэхдээ тийм юмыг нэгэнт хийчихсэн бол засах аргагүй.

- Чи тэгээд ямар хэрэг хийчихсэн юм бэ? – гэж Фродо тэсч ядан асуув.

- Би юу хэлчих вэ?- гээд мухлагийн эзэн хуруугаа инчдэн хэсэг зуур бодсоноо – Аа тийм, хуучин анд Гэндалф гурван сар орчмын өмнө манайд буусан юм. Нэг шөнө миний өрөөнд хаалга ч тогшилгүй орж ирээд: “Лавр минь, бид хоёр маргааш уулзаж чадахгүй, би гэгээ гарахаас өмнө явна. Чамд өгөх нэг даалгавар байна” гэлээ. Би “Арван даалгавар байсан ч билүүлнэ” гэв. Гэтэл тэр: “Чи Хоббитан руу захиа явуулж чадах уу? Найдвартай хүн олж чадах уу?” гэж байна. “Маргааш нөгөөдөр нэг хүн олно оо” гэлээ. “Нөгөөдөр шүү, битгий удаагаарай” гэсэн. Тэгээд надад нэг захиа өгсөн их энгийн бичсэн байна лээ”.

Тэгээд тэр халааснаасаа захиа гаргаж, их л чухал дүр үзүүлэн /тэр бичиг мэддэгтээ тун бардам байв/ хаягийг нь уншив:

ХОББИТАН, УУТАН ХЯСАА, ФРОДО ТОРБИНСТ

- Надад Гэндалфаас захиа ирсэн байна – гэж Фродо дуу алдлаа.

- Тэгэхлээр таны жинхэнэ нэр Торбинс байх нь ээ?

- Та өөрөө мэдэж байгаа шүү дээ. Наад захиагаа нааш нь өгөөд ямар учраас цагт нь явуулаагүй вэ гэдгээ тайлбарла. Энэ захиаг өгөх гэж л орж ирээ биз дээ? Их л удаан салгалж ирж дээ!

- Таны зөв өө, эзэн минь, дахиад л өршөөл гуйя – гэж Лавр хэлээд Гэндалф намайг яах бол гэж бодоход ч аймшигтай байна. Гэхдээ би буруу санаагүй юм шүү. Захиаг найдвартай газар хадгалаад илгээх боломж хайгаад л байлаа, боломж огт олддоггүй, тэгсээр ажилдаа дарагдаад мартаж орхижээ. Гэвч одоо би хичээж байна. Би алдаа гаргасан. Надаас хүсэх зүйл юу байна, шууд л хэлчих, тэр дор нь биелүүлнэ. Захианаас гадна бид хоёрт тохиролцоо бий. Тэр надад :”Лавр, Хоббитанаас чам дээр миний нэг найз ирнэ, нэрээ Накручинс гэж хэлнэ. Хоёул гурвуул ч ирж магадгүй. Илүү юм битгий асуугаарай. Гай зовлонд учирвал авраарай, мөнгө ч бүү хайрла, хүч ч бүү хайрла. Чи өөрөө мэднэ, надтай хамт байхад алзахгүй” гэсэн юм. Ингээд та нар хүрээд ирлээ, гэтэл гай газар дороос гараад ирлээ.

- Юун гай билээ? – гэж Фродо асуув.

- Энэ хар юмнуудын тухай ярьж байна аа – гэж эзэн дуугаа намсган хэлээд – тэд нар Торбинсыг асуусан, хэрэв сайн санаж асуусан бол би хоббит больё. Даваа гаригт ирцгээсэн юм. Ноход гасалж, улиад л, галуунууд гаагалж гуугалаад л, ямар аймаар байсан гэж санана,

үнэн шүү. Хоёр нь хаалгаар орох гэж зүтгээд. Торбинсыг гаргаад ир! гэж шуухитнаад. Толгойтой үс босох шиг болсон ч би тэднийг яаж ийгээд явуулсан: Зайлцгаа цаашаа, тэр Торбинс чинь, өөр юу ч бай хүссэн бүхэн чинь олдоно гэсэн. Тэд явах нь явсан, гэвч та нарыг Арчет хүртэл сураглаж явсан байна лээ. Нөгөө Мөрдөгчдөөс ирсэн хэн билээ, Тэнэмэл бас бас та нарын тухай асуусан, шууд дайраад ороод ирсэн, та нарыг хоол ч идүүлдэггүй, амраадаг ч үгүй.

- Дайрч орсон нь үнэн – гээд Тэнэмэл харанхуйгаас гарч ирэв – Лавр чи намайг оруулдаггүй чинь дэмий юм болсон доо, оруулсан бол чамд ингэж төвөг чирэгдэл гарахгүй байсан.

- Аа чи энд байна уу! – гээд мухлагийн эзэн бөмбөг шиг үсэрч – мөлхөөд ороод иржээ! Одоо чамд бас юу хэрэгтэй вэ?

- Тэр энд миний зөвшөөрлөөр орж ирсэн юм, тэр бидэнд туслах санал тавьж байна.

- Та нар өөрсдөө мэднэ биз дээ – гэж мухлагийн эзэн мөрөө хавчаад, Тэнэмэлийг сэжигтэйеэ харж – Чиний оронд би байсан бол Бөглүүдийн орноос ирсэн мөр шиншигчидтэй орооцолдохгүй л байсан даа.

- Та түүнд хэнтэй орооцолд гэж тушаамаар байна даа? – гэж Тэнэмэл шүднийхээ завсраар сийгүүлэн хэлээд - Өөрийнхөө нэрийг ч арай гэж санадаг, өдөржингөө нааш цааш нь дуудагдан гүйж байдаг өөхөө даахгүй мухлагчинтай юу? Эд нар чиний мухлагт мөнх түгжигдэхгүй, тэд буцах замаа захиалчихсан. Тэд цаашаа унаатай унаагүй явах л хэрэгтэй, маш хол явах хэрэгтэй. Эсвэл чи өөрөө эдэнтэй хамт явж, хар морьтнуудтай тулалдах юм уу?

- Би юу? Би Уулын суурингаас явна гэж үү? Хичнээн ч мөнгө өгсөн би явахгүй – гэж үхтлээ айсан мухлагчин үнэхээр өөрийг нь хамт явъя гэж байгаа юм шиг хэлээд – Гэхдээ ноён Накручинс та үнэхээр манайд жаахан хүлээх юм биш үү? Юундаа яардаг юм. Ер нь яагаад энэ хар айдсуудтай орооцолдсон юм бэ? Тэд хаанаас гараад ирсэн юм бэ?

- Тэд Мордороос ирсэн юм. Ойлгож байна уу Лавр? Мордороос – гэж Тэнэмэл дуулах төдий хэлэв.

- Яадаг билээ, аварч өршөө! – гээд Лавр Наркиссын царай айсандаа цайрав. Мордор гэдэг үг түүний ой тойнд их хүнд дарамт болдог нь илт. Аль дивангараас хойш Уулын сууринд үүнээс муу юм дуулдаагүй дээ.

- Дахиад дуулах болно – гэж Фродо хэлээд – гэвч та нар надад тусална гэж ямар ч гэсэн зөвшөөрч байгаа юм шив дээ?

- Туслалгүй яах вэ энэ чинь, тусална- гэж ноён Наркисс үгээ давхцуулан хэлээд – гэхдээ Тэдний эсрэг над шиг хүн ямар тус хүргэж чадахыг мэдэхгүй л байна... хэмээн түгдрэв.

- Дорноос ирэх Харанхуйн эсрэг – гэж Тэнэмэл баттай хэлээд- тус бага л даа, гэхдээ Лавр минь, гэхдээ байлгүй яахав, жишээ нь чи ноён Накручинсыг эндээ аймшиггүйгээр хонуулаад, жинхэнэ нэрийг нь дурсахгүй байж чадна.

- Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав – гэж мухлагийн эзэн илэрхий айсан царайтай ч эрс шийдэмгий толгой дохиод – гэхдээ би та нарт нэмэр болохгүй гэдгийг харуут мэдэж байгаа шүү дээ. Ноён Торбинс өнөөдөр өөрийгөө тэгж илрүүлсэн нь ямар харамсалтай вэ. Бильбогийн талаар энд бишгүйдээ нэг сонссон. Ноб хүртэл таныг хэн болохыг ойлгосон, манайд бас хурдан ойлгоцтой хүмүүс байна шүү.

- Итгэхээс дээ, морьтнууд одоохондоо ороод ирэхгүй биз – гэж Фродо хэлэв.

- Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав, итгэх хэрэгтэй – гэж Лавр яаран хэлээд тэд нар зуу дахин хий үзэгдэл байсан ч “Пони”-д шууд давхиад ороод ирэхгүй. Өглөө болтол тайван унтацгаа. Ноб та нарын талаар илүү үг дуугарахгүй, бид бүх байшингаараа энд янз бүрийн айдаснууд оруулахгүй манана.

- Үүрээр биднийг сэрээгээрэй, маш эрт гарах хэрэгтэй байна. Зургаа хагаст.

- Гүйцэтгэе! Захиалга бол захиалга! – гэж мухлагийн эзэн баярлан дуу алдаад – сайхан нойрсоорой ноён Торбинс, үгүй ээ, уучлаарай, Накручинс! Ингэхэд ноён Брендизайк хаана байна?

- Мэдэхгүй, гадуур зугаалж яваа юм байлгүй, салхинд гарна гэж хэлж байсан. Мерриг тэд мартчихсан, цаг орой болсон байлаа.

- Та нараас нүд салгахгүй байхаас – гэж Наркисс санаа алдаад – танай найзыг орж ирэхээр бүх хаалгыг түгж гэж тушаая, үүнийг Ноб гүйцэтгэнэ.

Эцэст нь эзэн Тэнэмэл рүү дахин нүдээ онийлгон харж, толгой сэгсрээд гарав. Хонгилд түүний алхаа нь холдсоор дуулдахаа болив.

- Чи захиагаа уншихгүй юм уу?- гэж Тэнэмэл асуув.

Фродо дугтуй дээрх тамгыг анхааралтай харвал яах аргагүй Гэндальфын тамга мөн байв. Захидлыг задлахад гаргацтай таталган бичжээ:

“ДҮҮХЭЛЗЭГЧ ПОНИ МОРЬ”, УУЛЫН СУУРИН.

Хоббитаны тооллоор 1418 он, тэргэл өдөр.

Эрхэм найз Фродо!

Надад муу мэдээ ирлээ. Яарч байна, цаг алга. Чи Уутан хясаанаас хурдан гар, хамгийн их оройтлоо гэхэд долдугаар сарын эцэс гэхэд Хоббитанд чиний амьсгаа ч байх ёсгүй. Би чадах цагтаа эргэж ирнэ, хожимдвол хөөж гүйцнэ. Уулын суурингаар дайрвал мэдээ үлдээгээрэй. Мухлагийн эзэнд /Наркисс/ итгэж болно. Замдаа миний найзтай уулзана гэж найдаж байна. Өндөр нуруутай, хар үстэй хүн байгаа, нэрийг нь Тэнэмэл гэдэг юм. Тэр бүхнийг мэднэ, бүх талаар тусална. Уудам хөндийд хүрээд оч, тэнд уулзана биз дээ. Хэрэв би амжиж очихгүй бол Элронд та нарт санаа тавьж, цаашид яахыг хэлж өгнө. Яарч байна, уучлаарай.

ГЭНДАЛЬФ

ЖИЧ: Тэрнийг битгий зүүгээрэй, ямар ч тохиолдолд зүүж болохгүй. Өдөр яваад, шөнө нуугдаарай.

Өөр нэг зүйл: Тэнэмэлтэй уулзахаараа болгоомжтой байгаарай, хэн ч өөрийгөө тэгж нэрлээд явж байж болно. Жинхэнэ нэрийг нь Арагорн гэдэг юм шүү.

Эртний алт гялалзах нь ховор

Эртний илдний үзүүр содон

Эрүүлч ноён тулаанд гарна:

Эрийн цээнд хүрнэ гэдэг

Элж өтлөхийн нэр биш.

Гай зовлон домог болно,

Гал мэт илд дахин улалзана,

Ноёны нэрийн өмнөөс

Ноёныг ноёноор нь дуудна.

ДАХИН ЖИЧ: Найдаж байна шүү. Лавр энэ захиаг хурдан илгээнэ. Хүн шиг л хүн, даанч ой той нь шүү шүүрэн шанага даа. Маргвал тэрнээр шөл хийнэ.

Аз хийморь тань бадраг!

Г.”.

Фродо захиаг уншаад Пинд өгч, уншчихаад түүнд өг гэж Сэм рүү дохилоо.

- Хөөрхий муу Наркисс ч хэрэг тарьж дээ. Гэндальф үнэхээр тэр хөөрхийгөөр шөл хийчихвэл яана! Ээ хөөрхий, би захиагаа цагт нь авсан бол аль хэдийн Уудам хөндийд оччихсон байхгүй юу. Гэндальф яасан юм бол? Тэр гал руу орох шахам байгаа юм бичсэн байна.

- Тэр их олон жил гал дундуур явж байгаа юм. Ямар ч эргэлзээгүйгээр, шууд – гэж Тэнэмэл хэлэв.

Фродо түүнрүү эргэж бодлогошронгуй хараад Гэндальфын “дахиад жич” гэж бичсэнийг санав.

- Чи яагаад түүний найз гэдгээ хэлээгүй юм бэ? Тэгээд л болох байсан шүү дээ.

- Чи тэгж бодож байна уу? Би хэлсэн гэж бодъё, тэгвэл миний үгэнд итгэх байсан уу? Миний

үг юу юм бэ? Захианы тухай би мэдэж байсан. Ер нь би та нарт өөрийнхөө тухай ярьж яах юм бэ? Эхлээд та нарыг хэн бэ гэдгийг чинь мэдэх ёстой. Дайсан байн байн надад хавх тавьдаг юм. Та нарыг танилаа. Тэгэхээр зарим нэг юмыг тайлбарлахад бэлэн байна, гэхдээ ямар ч тайлбаргүйгээр надад итгэх байх гэж найдаж байсан юм – гээд Тэнэмэл хачин инээмсэглэж – зарим үед дайсагнах, үл итгэх хоёроос болоод бүр ядарчих юм байна шүү дээ. Миний дүр төрх итгэж найдахад хэцүү л дээ.

- Тэр ч үнэн шүү -гэж захиаг уншиж дууссан Пин санаа амарсан янзтай инээж – манай Хоббитанд харцгын өдтэй хэрээний дотортой гэж ярьдаг юм. Хэрэв чи хоёр долоо хоног бүслэгдсэн бол гадаад байдал ямар байх нь ойлгомжтой.

Хэдэн долоо хоног бүслэлтэд байх бол юу ч биш. Мөрдөгчтэй адилхан болохын тулд олон жил Бөглүүдийн орноор тэнэх хэрэгтэй. Та нар тийм туршилтыг мэдэхгүй, мэдэхгүй чинь сайн хэрэг.

Пин түүнд итгэж, Сэм бас л үл итгэсэн харцаа Тэнэмэл рүү илгээж сууснаа:

- Чи Гэндальфын бичсэн тэр Тэнэмэл гэдгийг чинь бид юугаар мэдэх юм бэ? Хэрэв захиа байгаагүй бол чи Гэндальфын тухай дурсах ч үгүй байсан. Биднийг хаа нэг тийш нь дагуулж аваачихын тулд жинхэнэ Тэнэмэлийг нударчихаад орлон тоглож яваа ч юм уу. Энэ талаар чи юу хэлэх вэ?

- Чамайг амархан хуурч дөнгөхгүй юм байна гэж хэлье. Бас Сэм Скромби минь, хэрэв би жинхэнэ Тэнэмэлийг алчихсан бол чамайг суудлаасаа босолгүй нухчихна. Хэрэв би бөгжний хойноос хөөцөлдөж явсан бол аль хэдийн авчихсан байгаа гэж хэлье.

Тэр босоод иртэл улам өндөр болсон мэт харагдав. Нүдэнд нь хатуу ширүүн, эзэрхэг оч гялсхийв. Цуваа ярж, урьд нь огтхон ч ажиглагдаагүй эфес илднийхээ бариул дээр гараа тавихад хоббитууд хөдлөхөөсөө ч айж байлаа. Сэм түүн рүү амаа ангайн харав.

- Битгий айцгаа, би жинхэнэ Тэнэмэл нь байна – гэж тэр инээмсэглэн хэлээд – Арахорны Хүү Арагорн байна. Та нарын амь насны төлөө өөрийн амь насаар дэнчин тавих болно гэв.

Нэлээд удаан дуугүй байцгаасны эцэст Фродо:

- Захиаг уншихаасаа ч өмнө би чамайг анд нөхөр гэж мэдэж байсан. Яг таг мэдэхгүй ч гэсэн найдаж байсан байж магадгүй. Чи өнөө орой намайг нэг бус удаа айлгасан, гэхдээ энэ бол тэр мөс шиг хүйтэн айдас биш байсан. Чи тэдний нэг байсан бол өнгөн дээрээ сайхан загнаад өмхий санаагаа дотроо нуух байсан.

- Тийм дээ – гээд Тэнэмэл инээж- харин дотроо юу ч нууж яваа юм билээ хэн мэдэхэв, сайхан занг бол надаас горьдсоны гарз. Нэг үгээр бол эртний алт гялалзах нь ховор гэлээ.

- Энэ чинь чиний тухай шүлэг байх нь ээ – гэж Фродо асуугаад – юун шүлэг юм бол гэж гайхаад байсан юм. Гэндальф захиандаа чиний тухай бичсэн гэж яаж мэдэж байгаа юм бэ? Чи захиаг уншаагүй шүү дээ.

- Би мэдэхгүй ээ, зүгээр л би Арагорн, тэгэхлээр миний тухай шүлэг байж таарна.

Тэнэмэл илдээ хуйнаас нь сугалахад илд нь бараг бариулдаа хүртэл хугарсан байв.

- Хэрэг болохоосоо дараа болмоор эд байгаа биз дээ, тийм үү Сэм? – гэж тэр инээмсэглэн асуугаад – гэвч үүнийг дахин давтах цаг ойртож байна- гэлээ.

Сэм дуугарсангүй.

- За тэгэхээр, Сэмийн зөвшөөрлөөр Тэнэмэл та нарын газарч боллоо. Маргааш амаргүй зам туулна. Бид Уулын суурингаас саадгүй гарлаа ч гэсэн үзэгдэж харагдахгүй явна гэж байхгүй. Ядаж мөрөө буруулахыг хичээнэ. Эндээс гарах нэг хоёр нууц жим бий. Мөрдөгчдийг нохойн замаар оруулаад Эргүүлэг чиглэнэ дээ.

- Эргүүлэг ээ? Бас юун Эргүүлэг вэ? – гэж Сэм сэжиглэнгүй асуув.

- Тийм нэртэй уул байдаг юм, их замаас баруун талд. Тэндээс бүх юм харагдана – эргэж харъя л даа. Хэрэв Гэндалф бидний араас явж байгаа бол тэнд л очно. Эргүүлгээс цааш улам л бэрх, улам л аюултай болно.

- Чи Гэндалфтай хамгийн сүүлд хэзээ уулзсан бэ? одоо тэр хаана байгаа, түүнд юу тохиолдсон талаар мэдэх юм байна уу? – гэж Фродо асуув.

- Мэдэхгүй ээ, хавар бид хоёр баруунаас хамт ирсэн. Түүнийг өөр ажилтай байхад би олон жил Хоббитанийг хамгаалсан. Танай хил бараг хэзээ ч харуул хамгаалалттай байгаагүй. Сүүлийн удаа тавдугаар сард уулзахад та нарын ажил тодорхой болсон, есдүгээр сарын эцсээр Уудам хөндий рүү явна гэж байсан. Та нартай хамт яваа байх гэж би бодсон юм. Гэтэл өөр ажлаар явжээ. Хамт явсан бол их хэрэгтэй байсан юм. Түүнийг таньдаг болсноосоо хойш би анх удаа л түүнд санаа зовж байна. Өөрөө ирэхгүй ч гэсэн заавал мэдээ илгээх ёстой. Мэдээ байдаггүй, эцэст нь Гэндалф сураггүй болсон, Хоббитанаар хар морьтнууд хөлхөлдөж байна гэж би дуулсан юм. Харальдын эльфүүд надад хэлсэн юм, та нарыг Забрэнди рүү явсан гэж тэднээс дуулаад би баруун замыг харуулдахаар шийдсэн юм.

- Хар морьтнууд Гэндалфыг барьсан гэж чи бодож байна уу?

- Хэрэв тэд биш бол Дайсан өөрөө барьсан байж мэднэ. Түүнийг барих хүчтэн өөр байхгүй. Гэхдээ санаагаар унаж болохгүй, хараа дээгүүр бай! Та нар Хоббитандаа байхдаа Гэндалф гэж хэн болохыг мэдээгүй, зөвхөн түүний шог наргиа, элдэв хөгжилтэй тоглоомуудыг л мэднэ. Энэ удаа түүний зорилт ердийнхөөсөө илүү аюултай.

- Ёох, уучлаарай – гээд Пин эвшээлгээж – би үхлээ ядарч байна. Айдас түгшүүр, ажил төрлөө маргааш больё, одоо би хэвлээ, тэгэхгүй бол босоогоороо унтах нь. Золгүй илжиг Мерри хааччихав аа? Харанхуйд тэрнийг хайх болбол маргааш толгойг нь тасдана аа.

Пинийг хэлж дуусаагүй шахам байтал хонгилоор яаран алхах чимээ сонсдоноо Мерри өрөөнд дайрах шахам орж, араас нь сандарсан Ноб орж ирлээ. Мерри арайхийн амьсгаагаа

дарж:

- Би тэднийг харлаа Фродо! Харсан шүү! Тэд – хар морьгнууд энд байна!

- Хар морьгнууд аа! – гээд Фродо босон харайв - Хаана?

Энд л байхгүй юу, суурин дотор. Би галын дэргэд цаг орчим суугаад та нарыг орж ирэхгүй болохоор зугаалахаар гарсан юм. Дэнлүүний дэргэд зогсоод од харж байлаа. Гэнэт хамаг бие чичирч, ямар нэг аймшгийн муухай юм над руу гэтэж, дэнлүүний гэрлийн гаднах харанхуйг нэг хар толбо нүхлэх шиг болсон. Үзэгдэнгүүтээ хаа нэг тийш өтгөн харанхуй руу алга болсон. Морь байгаагүй.

- Хаашаа алга болчихов? – гэж Тэнэмэл болгоомжтой мөртөө эрсхэн асуув.

Мерри гадны хүнийг хараад цочин давхийв.

- Ярь ярь, энэ бол Гэндалфын найз. Дараа тайлбарлая.

- Их зам руу л явчих шиг болсон. Би араас нь мөрдөхөөр шийдсэн, харин хэний юм уу, юуны араас мөрдөж байгаагаа мэдээгүй, гудамжны үзүүрээр тойроод замын хажуугийн хамгийн захын байшин хүртэл явлаа.

- Чи зоригтой эр байна – гээд Тэнэмэл Мерриг гайхан харж – гэхдээ энэ бол маш тэнэг явдал гэв.

- Онцгой зориг юм уу, онцгой тэнэглэл надаас шаардагдаагүй, би зүгээр л өөрөө ч мэдэлгүй тийшээ явсан, намайг тийш нь татаад байсан, тэгээд л тэр. Хаашаа явж байгаагаа ч мэдээгүй, гэнэт ухаан орох шиг болсон – яг хажууханд хоёр дуу хоолой яриад байсан. Нэг нь хачин исгэрээтэй шуухитнаад, хариуд нь нөгөө нь ойлгомжгүй бувтнаад байсан.

Би юу ч ойлгоогүй. Ойртох гэхээр зориг дутаад, зугтаая гэхээр хөл хөдөлдөггүй. Чичрээд л зогсоод байснаа эргээд хар хурдаараа гүйх гэтэл араас аймшиг ойртсон... тэгээд би уначих шиг л болсон.

- Би энэ хүнийг олсон юм аа эзэнтээн, ноён Наркисс надад дэнлүү барьж яваад түүнийг олоод ир гэсэн юм. Би эхлээд баруун хаалга, дараа нь өмнөд хаалга хүртэл эрсэн. Цохиур Бургасны байшингийн дэргэд, хашааны ёроолд хоёр амьтан нэг хүний дээрээс бөхийж, чирч явах гээд байгаа харагдсан юм. Би ч “Харуул” гэж хашгираад тийшээ гүйгээд очтол хэн ч байдаггүй, ноён Брендизайк л зам дээр унтаж байгаа юм шиг хэвтэж байлаа. Би түүнийг сэгсэртэл арай гэж сэргээд “Би живсэн, ёроолд хэвтэж байна” гэж хачин эвгүй шивнээд, хөдлөөд байсан. Би яахаа мэдэхгүй наашаа цаашаа гүйж байтал тэр гэнэт босон харайгаад “Пони” руу сум шиг хурдалсан, араас нь хөөгөөд гүйцдэггүй шүү.

- Ийм л юм болсон байх, би тэнд юу авч явснаа мэдэхгүй, үхлээс ч аймшигтай зүүд байсан, ямар зүүд байсныг ч санахгүй байна, тэр нь ч дээр. Намайг нэг тийш нь чангаагаад л байсан.

- Булшны нүх рүү чангаачих дөхөж дээ – гэж Тэнэмэл тодруулаад – тэд нэг газар морьдоо

орхиод өмнөд хаалгаар суурин руу орсон байна. Цохиураас тэд сүүлийн үеийн бүх мэдээг авсан. Хялар ч гэсэн тагнуул мөн. Хөгжилтэйхэн шөнө болно доо.

- Юу болно гэж? Мухлаг руу дайрах уу? – гэж Мерри асуув.

- Тэр ч арай үгүй болов уу, бүгдээрээ ирж амжаагүй байгаа, тэгээд ч тэд тэгж ажилладаггүй. Тэдэнд нам гүм, харанхуй газар л хэрэгтэй. Том байшин, үймээн шуугиан, гал, олон хүн тэдэнд хэрэггүй. Бидний зам урт, цаг ч байна. Өөрсдөө довтлохгүй, гэвч энд тэдний гар хөл болох амьтад зөндөө. Зарим нь дуртайдаа, зарим нь айсандаа тусална. Тэр муу Цохиур, өмнөдийн таван тагнуул, манаач Горри гээд л. Морьгнууд эндээс явахдаа миний нүдний өмнө манаачтай яриад байсан, тэр шохой шиг цагаан болчихсон, өвдөг нь чичрээд байсан – гэж Тэнэмэл өгүүлэв.

- Эргэн тойрон дайсан байна, одоо яах вэ – гэж Фродо асуув.

- Унтлагын өрөөгөөр тарахгүй, эндээ унтана! Та нарын унтлагын өрөө хаана байгааг тэд аль хэдийн мэдчихсэн – хойшоо харсан, бараг газартай нийлсэн дугариг цонх. Эндээ үлдээд цонхны хаалтыг буулгаад, хаалганы бүх түгжээг түгжинэ. Одоо Ноб бид хоёр та нарын бүх юмыг аваад ирье – гэж Тэнэмэл хэлэв.

Тэр хоёр гарч, Фродо энэ үдэш болсон бүхнийг Меррид товчхон ярьж өглөө. Тэнэмэл, Ноб хоёрыг эргэж ирэхэд Мерри Гэндальфын захиаг уншиж, өөрийн дүгнэлтээ хийж байлаа.

- Тэгэхлээр ноёд зочид оо, би та нарын хөнжилд буйдангийн түшлэг ороогоод хүн унтаж байгаа юм шиг болголоо, бас та нарын толгойтой адилхан хүрэн ноосон бүтээлгийг бөөрөнхийлөөд хөнжилд шургуулчихлаа ноён Тор...уучлаарай Накручинс – гэж Ноб инээвхийлэн өгүүлэв.

- Харанхуйд ялгахгүй – гэж Пин инээгээд – харин таньсан хойноо яах бол?

- Цаг дээр нь л харъя, өглөө болтол яаж ийгээд тэсэх байх аа – гэж Тэнэмэл хэлэв.

Тэд үүргийн шуудайнуудаа шалан дээр тавиад, хаалгаа түгжин наанаас нь буйдан сандлаар шахаад цонхны хаалтыг буулгав. Фродо хаалт буулгахдаа тодоор яралзан буй оддыг зэрвэсхэн харлаа. Уулын орой дээгүүр хоббитуудын “хадуур од” гэж нэрлэдэг долоон бурхан тодоос тод гялалзан байв. Фродо хүндээр санаа алдаад хүнд хаалтыг буулгаж, хөшгийг нь татлаа. Тэнэмэл задгай зууханд гал асааж, лааг унтраав.

Хоббитууд гал руу хөлөө харуулан шалан дээр хэвтэж, Тэнэмэл хаалганы дэргэдэх буйдан дээр суув. Бараг ярилцсангүй. Ганц Мерри асуулт тавилаа.

- “Үнээ шувуу шиг хөөрч”- гэж тэр хөнжлөөр хучих зуураа уншаад хөхөрч - Фродо минь өөрөө ойчсон хүүхэд уйлдаггүй, тэсэх л хэрэгтэй болж дээ, би тэнд байгаагүй нь тун ч тоогүй. За яахав, эндхийнхэн лав зуун жил ярих юмтай боллоо.

- Үүнд итгэлтэй байж болно – гэж Тэнэмэл хэлсний дараа бүгд чимээгүй болж, хоббитууд

цувран унтав.

Бүлэг 11

Шөнийн илд

Тэднийг Уулын суурингийн мухлагт унтахаар бэлтгэж байхад Забрэндид манан, харанхуй хоёр холилдсон тун ч таагүй шөнө болж байлаа. Молтогчингийн судагт нам гүм. Бүдүүн Минж хаалгаа өчүүхэн нээгээд хамраа болгоомжтой цухуйлгав. Өдөржин нэг л аймшигтай байсан бөгөөд орой болоход тэр унтахгүй гэж шийдсэн байлаа. Нам гүм агаарт далд аюул нуугдаж байв. Тэр манант харанхуй руу харж байтал хашааны хаалга өөрөө чимээгүй нээгдсэнээ эргээд чимээгүй хаагдав. Тэр амьдралдаа хэзээ ч айж байгаагүйгээр айлаа. Бүдүүн чичрэн байж арагшаа огло үсрээд биеэ сэгсэрч хөшөөгөө гаргаад дараа нь хаалгаа хааж, бүх түгжээг түгжив.

Шөнө улам харанхуйлсаар. Туурайн бүдэг чимээ сонсдов. Нугаар морь хөтөлж яваа бололтой. Туурайн чимээ хаалганд тулаад зогсч, гурван хар толбо харанхуйг нүхлэн гарч ирээд, нэг нь хаалга руу ойртож, хоёр нь байшингийн хоёр буланд зогсов. Хар толбонууд нуугдаж, улам нам гүм болов. Шөнө төгсгөлгүй үргэлжилж, байшингийн гаднах модод чив чимээгүй хүлээн байх мэт.

Гэтэл навчин дээгүүр салхин гүйж, хаа нэгтээ эхний тахиа донгодов. Үүрийн өмнөх аймшигтай цаг өнгөрлөө. Хаалганы дэргэдэх толбо хөдлөв. Од ч үгүй, сар ч үгүй харанхуй манан дунд хуйнаас сугалсан илд гялсхийв. Зөөлөн боловч хүнд цохилт хаалга ганхууллаа.

- Мордорын нэрээр нээ! - гэж хорсол дүүрэн хий хоолой зандрав. Хоёр дахь цохилтоор хаалга гинж, дэгээ, түгжээтэйгээ нуран уналаа. Хар толбонууд дотогш оров.

Тэгмэгц ойролцоох төгөлд эвэр бүрээ цангиналаа. Бүрээн дуу харанхуй шөнийг цахилгаан мэт нэвт сүлбэн:

БОСООРОЙ! ДАЙРАЛТ! ТҮЙМЭР! ДАЙСНУУД ! хэмээн цангиналаа.

Бүдүүн Минж байшинд байсангүй. Хар толбонууд хаалга руу мөлхөж байгааг хараад тэр нэг бол зугтаана, нэг бол үхнэ гэдгээ ойлгожээ. Тэгээд арын хаалгаар гарч, цэцэрлэг, ногооны талбайгаар дамжин зугтаажээ. Ойрын байшин хүртэл хоёр лиг газар гүйгээд довжоон дээр унаж:

- Үгүй, үгүй, үгүй! Би хамаагүй! Тэр чинь надад байхгүй! – хэмээн ёолов. Тэр юугаа бувтнаад байгааг ойлгосонгүй, гэвч Забрэндид дайснууд ирсэн байна, Мөнхийн ойгоос довтолжээ гэж ойлгоцгоов. Тэгээд л:

ДАЙРАЛТ! ТҮЙМЭР! ДАЙСНУУД! ШАТАЖ БАЙНА!

гэсэн түгшүүрийн дохио хангинуулжээ. Брендизайкууд хахир өвлийн цагаар хөлдсөн голын дээгүүр умраас цагаан чононууд довтолсноос хойш лав зуун жил үлээгээгүй хуучны эвэр бүрээ, дохионы бүрээнүүдээ үлээв.

БОСООРОЙ! ДАЙСНУУД!

Хаа нэгтгээгээс хариу дуудлага өглөө. Түгшүүрийг ном дүрмийн дагуу зарлалаа. Хар толбонууд байшингаас мөлхөн гарав. Довжоон дээр цоо цоо сүлбэсэн хоббит цув үлдэв. Туурайн төвөргөөн намдсанаа манан руу цогих чимээ гарав. Энд тэндгүй эвэр бүрээ цангинаж, бие биеэ дуудалцан хоббитууд гүйлдэв. Гэвч хар морьгнууд умар зүг рүү хуй салхи мэт хурдлан зугтаав.

Муусайн жижигхэн ардууд эндээ орилцгоож л байг. Цаг нь болохоор Саурон эдний учрыг олно. Харин одоо өөр ажил байна. Байшин эзгүй байсан, бөгж байхгүй, цаашаа эрэх хэрэгтэй! Тэд хэрмийн хаалганы манаачийг мориороо гишгүүлээд хоббитын хязгаараас алга болов.

Үүрээс өмнөхөн Фродо хэн нэгэн түүнийг дуудсан юм шиг гэнэт цочин сэрэв. Харвал Тэнэмэл сэрэмжлэн чагнаж, нүд нь урьдын адил улалзан буй галын гэрэлд гялалзан, биеэ хөвчлөн хөдөлгөөнгүй сууж байлаа.

Дараа нь Фродо дахин унтлаа, гэвч түүний нойронд салхи хүүгэх, туурай тачигнах чимээ харван орж ирэв. Шуурга дэн буудлын байшинг ганхуулан хаа нэгтээ алсад эвэр бүрээн дуу хадав. Фродо нойрыг үлдэн хөөгөөд нүдээ нээж, хашаан дотор тахиа донгодохыг сонсов. Тэнэмэл цонхны хөшгийг яраад, хаалтыг огцом өргөн, дараа нь цонхоо нээв. Үүрийн саарал гэгээ өрөө дүүрэн, өглөөний хүйтэн хөнжил доогуур шургалаа.

Тэд Тэнэмэлийн араас даган хонгилоор явж унтлагын өрөөнд ортол түүний зөвлөгөө тэдний амийг аварсан болохыг ойлголоо. Цонх эвдрэн дэгээн дээрээ санжиж, хүү хүү татсан хөшиг салхинд дэрвэж, сэг болтол сийчсэн буйдангийн түшлэгнүүд шалан дээр хөглөрч, тарааж хаясан орны даавуунууд дунд сэг болсон хүрэн бүтээлгүүд хэвтэнэ. Тэнэмэл тэр дороо эзэн рүү явлаа. Хөөрхий Лавр айсан нүдээ цавчлах бөгөөд өөрийнх нь хэлснээр бол өнгөрсөн шөнө нүдээ огт аниагүй, эргэн тойрон чив чимээгүй, нам гүм байсан гэнэ.

- Амьдралдаа ийм юм үзсэнгүй - хэмээн тэр айсандаа гараа тааз өөд өргөж – зочид орондоо унтахад аюултай, бараг цоо шинэ түшлэг, ор дэрний хэрэгслүүдийг сүйтгэж байхыг үзсэнгүй. Цаашдаа юу болно гэсэн үг вэ? – хэмээн халаглав.

- Ямар ч сайн юм болохгүй, гэвч биднээс хагацахаар чамд тайван болно оо. Бид одоо хөдөллөө. Өглөөний хоол хэрэггүй, замдаа ямар нэг юм идчихнэ – гэж Тэнэмэл хэлэв.

Наркисс морьдыг эмээллэн гаргаж ирэх, замын хүнс бэлтгэхийг тушаахаар гүйж одов. Гэвч байдгаараа сандарчихсан орж ирлээ. Пони морьд алга болчихжээ! Жүчээний хаалга цэлийтэл нээлттэй, дотор нь хов хоосон байна гэнэ. Хоббитуудын пони морьд төдийгүй жүчээнд байсан бүх морьд алга болжээ.

Фродо бүрмөсөн сэтгэлээр унав. Морьтой дайснууд хөөж байхад яаж Уудам хөндий орох юм бэ? Тэгснээс сар руу явах юм уу, од болсон нь амархан. Тэнэмэл хоббитуудын хүч, шийдэмгий байдлыг цэгнэх мэт тэднийг тойруулан харав.

- Тэртэй тэргүй пони морьгнуудаас аврахгүй – гэж тэр Фродогийн санааг таасан бололтой хэлээд – та нарыг дагуулж явах тэр замаар понитой явснаас явган явсан нь дээр. Замын хүнс яасан? Уудам хөндий хүртэл дахиад бид хүнсний нөөц нэмэхгүй, аль болохоор их хүнс авах хэрэгтэй, замд саатаж болно, тойруу замаар явж ч магадгүй. Та нар хэр зэрэг их ачаа үүрч даах вэ?

- Хичнээнийг л бол хичнээнийг – гэж Пин зоригтой хэлсэн боловч зүрх нь ёгхийх шиг болов.

- Хоёр хүний үүрэхийг даана – гэж Сэм баргар царайлав.

- Та юугаар тусалж чадах вэ ноён Наркисс? Ачаа ачих хоёр юм уу, ганц пони олж чадах уу? Хөлслүүлэхгүй байх гэж бодож байна, худалдах болов уу? –гээд Фродо байгаа мөнгөө санаандаа тоолов.

Эргэлзэж байна, Уулын суурингийн бүх пони - хоёр билүү, гурав ч билүү манай жүчээнд байсан юм, хоёрхон морь байсан юм, одоо үлдсэн нь худалдах морьд биш. Хичээгээд үзье. Би одоохон залхуу Бобыг олоодохье, тэр яваад асуугаад ирэг.

- За яахав, асуугаад ирэг. Нэг пони бидэнд ямар ч байсан хэрэгтэй. Одоо эрт, нууцаар гарах тухай бодох ч хэрэггүй. Пони хайна гэдэг түгшүүрийн бүрээ үлээсэнтэй адил, тэд ч тэгж тооцоолсон бололтой – гэж Тэнэмэл хэлэв.

- Тайвшрах нэг өчүүхэн боломж байна – гэж Мерри хэлээд – эрүүл саруулаар сэтгэх юм бол тийм ч бага боломж биш, нэгэнт ийм болсон юм чинь өглөөний хоолоо зохих ёсоор нь идье. Хожуул Ноб хаана байна?- гэж санал дэвшүүлэв.

Тэд гурван цаг гаруй саатлаа. Боб эргэж ирээд, худалдах адуу юм уу, пони нэг ч алга, зөвхөн Цохиур л нэг зөнөсөн адгуус худалдахыг зөвшөөрч байна гэсэн мэдээ дуулгав.

- Арьс яс хоёр л байна, аль хэдийн арьсыг нь амьдаар нь хуулах болчихсон пони байна. Гэтэл Цохиур гурав дахин өндөр үнэ хэлж байна, мөнгөний үнэр авчихаж л дээ, хар тулам чинь – гэж Боб хэлэв.

- Цохиур гэнэ ээ? Энд нэг юм байна даа. Нэг бол тэр пони манай ачааг аваад эргэж зугтаана, эсвэл тэр понигоороо дамжуулж биднийг мөрдөх ч юм уу, юу ч болж мэднэ – гэж Фродо болгоомжлов.

- Магадгүй, магадгүй – гэж Тэнэмэл зөвшөөрөөд – гэхдээ үгүй л болов уу. Цохиурын гараас нэг мултарсан адгуус буцаад очно гэж байхгүй. Тэр зүгээр л сул мөнгө тонших гэж байгаа байх. Тэр пони нь сүүлчийн амьсгалаа авч байгаа л даа. Тэглээ гээд бидэнд сонголт алга. Тэр хэдийг нэхэж байна?

- Цохиур арван хоёр мөнгөн зоос нэхэж байна, үнэндээ энэ бол тарган залуу понийн үнээс гурав дахин их мөнгө.

Худалдаж авсан адгуус нь яс арьс болсон, толгойгоо ч даахгүй шахуу, мартагдсан амьтан

байсан боловч үхэх тухай хараахан бодоогүй бололтой. Лавр Наркисс түүний үнийг өөрөөсөө төлөөд дээр нь алга болсон понинуудын төлбөр арван найман мөнгөн зоос Меррид өгөв. Тэр үнэнч шударга, хангалттай чинээлэг хүн боловч гучин мөнгөн зоос түүний хувьд енгэнэтэл уйлмаар харамсалтай, ядаж хагасыг нь хогийн новш, шуналын тулам Цохиурт өгч байгаа нь бүр ч харамсалтай байлаа.

Гэвч тэр алдсангүй, харин ч хожжээ. Хулгайч нар зөвхөн морьдыг аваад, понинуудыг зүгээр л үргээгээд хөөчихжээ. Дараа нь Уулын суурингийн дэргэдэх нугад идээшилж байгаад олдсон, харин Меррийн таван пони Том Бомбадилынд гүйгээд хүрчихжээ. Тэд тэнд дураар бэлчээрлэн арьсаа язартал таргалсан ба Том Уулын сууринд болсон явдлыг сонсоод тэднийг Наркисс руу буцааж хүргүүлжээ. Понинууд тэнд дураараа бэлчээрлээгүй боловч Боб тэднийг сайн маллаж, таван адгуус аймшигт аяллаас амьд мэнд зайлсан боловч Уудам хөндийг үзээгүй билээ.

Гэвч энэ бол дараа нь болсон үйл явдал, одоохондоо Лаврын мөнгө газрын гаваар орсон уу, салхинд хийссэн үү, бүү мэд. Өөр санаа зовоох юм хангалттай байв. Шөнө мухлаг руу дайрсныг сонсоод үйлчлүүлэгчид нь бөөн шуугиан дэгдээв. Өмнөдөөс ирсэн хэдэн зочны хэдэн морь алга болсон учир тэд мухлагийн эзнийг байдаг хоолойгоороо харааж зүхэж байсан боловч тэдний нэг нь шөнө гараад алга болчихсон, тэр нь Цохиурын найз Хялар байсан тул бүх юм тодорхой болж, тэд тэгсгээд дуугүй болов.

- Хэрэв та нар замдаа морины хулгайч нарыг элсүүлээд, тэднийгээ надад манай хүн гэж танилцуулсан бол тэр хулгайч нарынхаа өмнөөс хохирлыг барагдуул, над руу орилоод байх хэрэггүй. Тэр Цохиур руу очоод найз чинь хаачсан бэ гэж асуу!- гэж Наркисс даналзав.

Гэтэл тэр хялар хэний ч найз биш, хэзээ ч хүрээд ирсэн юм, хэн ч мэдэхгүй болж таарав.

Өглөөний хоолны дараа хоббитууд ачаагаа асар хол замд явгаар явахад тохируулж дахин боож баглав. Хоол хүнсний нөөц маш их нэмэгджээ. Тэд арван цагийн орчимд хөдлөв. Уулын суурин аль хэдийн сэрж, сандаачсан зөгийн үүр шиг дүнгэнэж байлаа. Хар морьтнууд ирсэн, Фродо алга болсон, морьд хулгайлсан, хамгийн сүүлчийн ухаан алдмаар сонин мэдээ нь Тэнэмэлийг Хоббитанаас ирсэн нууцлаг хоббитууд газарчаар хөлсөлсөн тухай байлаа. Мухлагийн дэргэд үй олон ард цугларч, ойрын суурингуудаас ч ирцгээж, цэц булаалдан аянчдыг замдаа гарахыг хүлээж байлаа. Дэн буудалд буугчид хаалганы хажууд гозойж, цонхоор цухалзаж байв.

Тэнэмэл төлөвлөгөөгөө өөрчилж, Уулын суурингаас шууд Их зам руу орохоор шийдэв. Шууд эргэх боломжгүй болсон, тэдний араас урт сүүл дагаж, тэднийг хаашаа явахыг нь харна, хэний ч биш газар руу оруулахгүйг хичээнэ. Ноб, Боб хоёртой салах ёс хийгээд, Наркисстай салах ёс хийж, баахан баяр талархлаар түүнийг булав.

- Сайн цаг иртэл салж байна гэж найдаж байна. Би танайд удаан зочлуулмаар л байна, тийм цаг ирж ч магадгүй – гэж Фродо хэлэв.

Цугларсан олны муухай харцан дор, түгшүүртэй, урамгүй хөдөлцгөөв. Ганц нэг хүн сайн явахын ерөөл хэлсэн боловч муу үг ч сонсдож байв. Тэнэмэл тоглоомд дургүйг бүгдээрээ

мэддэг, тэр хэн нэгэн рүү харцаа чиглүүлбэл тэр дороо нам болцгоож байлаа. Тэр Фродотой зэрэгцэн түрүүлж, араас нь Пин, Мерри хоёр явж, Сэм ард нь тааруулсан боловч нэлээд хүнд ачаатай пони хөтлөн явна. Хөөрхий адгуус хувь заяанд нь эргэлт гарсныг мэдэрсэн бололтой санаснаас сэргэлэн алхална. Сэм бодол болж, ам нь хөдлөн явна. Боб, Ноб хоёрын өгсөн алим халааснуудаар нь дүүрэн байлаа.

- Алим идэж алхаад л, тамхи сорж суугаад л, сайхан байна аа, даанч замын турш идэх алим нөөцөлж болохгүй юм даа – гэж тэр бувгнав.

Тэгсгээд тэд хашаа, хаалганы цаанаас байсхийгээд л толгойгоо булталзуулах сониуч амьтдыг анзаарахаа болив.

Нурж унахаа дөхсөн, яйжгар сүүлчийн байшинг бат бэх гуалин хашаагаар хүрээлсэн байлаа. Цонх шиг юмаар нь хялар нүдтэй, шаравгар нүүр харагдаад өнгөрөв.

“Аа, нөгөө өмнөдийн хялар энд нуугдаж байгаа юм байна... Харваас Бильбогийн хэлсэн орх яг мөн дөө” – гэж Фродо бодлоо.

Хашаан дээр тохойлдсон хөмсөг ихт, будангуй нүдэт, хулигаан царайтай, том биетэй эр дарвайтлаа инээж байв. Тэд аянчдыг явж өнгөрсний дараа гаансаа амнаасаа авч, том шүлс хаяв.

- Сайн уу, урт хөлт өө! Найз нараа олоо юу? – гэж тэр асуув.

Тэнэмэл хариу хэлсэнгүй.

- Та нарт ч гэсэн мэнд хүргэе маанаг өөдөснүүд ээ – гэж тэр хоббитуудад хандаж хэлээд – та нар хэнтэй орооцолдсоноо мэдэж байна уу? Энэ чинь Цагаандаа гарсан Тэнэмэл, ойлгов уу? Энэнээс өөр нэр ч бий, хэлэх дур алга. Шөнө болохоор та нар юу болохыг өөрсдөө үзнэ ээ! Хөөе чи Сэмхэн, миний муу амьсгаа болсон пониг битгий гомдоогоорой, Түй! – гээд тэр дахин том гэгч шүлс хаяв.

Сэм эргэж хараад:

- Цохиур чи өмхий нүүрээ далд оруул, тэгэхгүй бол юу болохыг мэдэх үү? – гэхэд том алимны хагас нь Цохиурын хамарт тусч, тэр нүд ирмэх зуур далд орсон ба хашаан дотроос хожимдсон хараалын үгс урсав.

- Амттай алим байсан юмсан – гэж Сэм санаа алдав.

Суурин дууслаа. Тэдний араас дагаж явсан хүүхдүүд болон хийх юмгүй уйдсан амьтад хоцорч, буцаад өмнөд хаалга руу гэлдэрцгээлээ. Баруун, зүүн тийш тахирласан Их замаар гурван лиг орчим алхаад, дараа нь зам өтгөн ойг огтлон налуу руу оров. Хүрэн өнгөт Уулын суурин ард хоцорч, тэд хойд зүг рүү үзэгдэх төдий бүдэг жимээр эргэв.

- Энд бид хөндлөнгийн нүднээс нуугдана – гэж Тэнэмэл хэллээ.

- Гэхдээ дөт зам биш байна, нэг удаа бид ойгоор шууд чигээрээ яваад арайхийж гарч ирсэн – гэж Пин эргэлзэнгүй хэлэхэд:

- Тэгэхэд би та нартай хамт байгаагүй, миний хувьд бүх тойруу зам шууд хэрэгтэй газарт хүргэдэг юм- гэж Тэнэмэл мушилзав.

Тэр хоосон Их замыг дахин нэг эргэж хараад, миний араас түргэл гэсэн дохио өгч бутархаг ой руу оров. Эндхийн газрыг тэд мэдэхгүй учир тэр ямар санаа сэдсэнийг ойлгосонгүй. Нэг л юм тодорхой байсан нь тэр эхлээд Четбор буюу хуучнаар Арчет чиглэн явж байгаад дараа нь баруун тийш эргэж Дорнод болон Бөглүүдийн орон руу эргээд Эргүүлэг тийш явахаар шийдсэнийг мэдэж байв. Тэд Шумуулт намгийг алсуур тойрсон Их замын олон салааг гаталлаа. Тэгсэн мөртөө яг тэр намаг руу орсон нь Тэнэмэлийн тайлбарласнаар “шинэ мэдээ дуулгасанд баярлалаа” ажээ.

Одоохондоо явах дуртай л байлаа. Өнгөрсөн шөнийн түгшүүр байгаагүй бол их л сайхан байлаа. Нар зөөлнөөр ээж, халуунаар шарахгүй байв. Хөндийн ой тэр чигээрээ олон өнгөт навчист умбаж, намуун тайван, баян тансаг байлаа. Тэнэмэл тэднийг сүлжилдсэн жимүүдээр итгэлтэй хөтөлж байсан бөгөөд Тэнэмэл байхгүй сэн бол тэд яагаад ч зөв жимээр орохгүй байлаа. Тэр бас араас хөөгсдийг төөрүүлэхийн тулд ийш тийш сүлжин явж байв.

- Цохиур биднийг хаана замаас гарсныг харсан, гэхдээ өөрөө араас дагахгүй, хэн нэгэнд хэлж өгнө. Тэр намайг гүйцэхгүй боловч эндхийн жимүүдийг муугүй мэднэ. Хөөх этгээдүүд нь холгүй байгаа. Бид Арчет явах хэрэгтэй болохоор тэд биднийг шууд Арчет руу явсан гэж бодог.

Тэнэмэл үнэхээр тэгж чадсан уу, яасан араас нь хөөсөнгүй, аянчдыг шувуу, үнэг, гавшгай хэрэмнүүд л ажиглаж байлаа. Тэд ойд хоноод өглөө нь чимээгүйхэн аянаа үргэлжлүүлэв. Ойгоос тэд зөвхөн гурав дахь өдрөө гарч ирээд нуугдлаа. Уулын суурингийн тариалан, бэлчээрийг өнгөрч Шумуулт намаг эхэллээ.

Хөл дорх намагт хөрс шал шалхийж, мөрийг нь булингарт ус дүүргэн баллаж, зэгсэн дотроос жижиг шувууд сүр сархийн нисэлдэнэ. Хоббитууд эхэндээ сэргэлэн, итгэлтэй алхаж байснаа дараа нь довонгоос довонд хальтран харайж байлаа. Энд мөрдөгчид хүртэл зам мэдэхгүй бөгөөд аз туршин явдаг ажээ. Тэдэн рүү шумуулууд довтолж, толгой дээгүүр нь үй олноороо эргэлдэн, үс, ханцуй, өмд рүү нь орж, хазаж, хатгаж байлаа.

- Намайг амьдаар минь идчих нь байна. Энэ бол Шумуулт намаг биш, шумуулын эзэнт улс байна – гэж Пин тэссэнгүй хэлэв.

- Хэрэв ойр хавьд хоббит байхгүй бол энэ новшнууд хэний цусыг уудаг юм бол? – гээд Сэм хүзүү рүүгээ алгадлаа.

Энэ бөглүүд газарт ховорхон муухай өдөр таарч, шөнө нь ч гэсэн хүйтэн, нойтон, тав тухгүй байсан ба шунгинадаг цус сорогчид нүд аних зав өгөхгүй байв. Зэгсэнд бас дэвхэрэгтэй төстэй нэг хачин дэвхэрдэг юмаар буцалж байв. Бүхэл шөнөжин “ццусс”, “ццусс”, “ццусс” гэсэн чимээ тэдний сонсголыг тамлав. Өглөө гэхэд хоббитууд бүр туйлдчихсан байв.

Дөрөв дэх өдөр, шөнө хоёр ч нэг их дээрдсэнгүй. Сэмийн “цус гуйгчид” гэж нэрлэсэн шавьжнууд, шумуулнууд ханаж цаддаггүй үүл болон толгой дээгүүр нь шунгинан эргэлдсээр. Туйлдаа хүртэл ядарч, бараг унтах найдваргүй болсон Фродо унтахаар хэвтгэл дорно зүгт гэнэт алсын гэрэл асч, унтарч байгаа харагдав. Үүр цайх хүртэл дахиад хэдэн цагийн зай байлаа...

- Энэ юун анивалздаг гэрэл вэ? гэж тэр нойтон харанхуй руу харан зогсч байгаа Тэнэмэлээс асуув.

- Хэтэрхий хол байна, мэдэх аргагүй, хачин юм, толгойн оройг аянга ниргээд л байгаа юм шиг – гэж тэр хэллээ.

Фродо хэвтсэн боловч тод анивалзах гэрэл, Тэнэмэл хоёрыг харсаар байв. Эцэст нь хүнд нойр түүнийг дийллээ.

Тав дахь өдөр нь намгархаг хөндий, зэгс ард үлдэж, удаан, ядаргаатай өгсөлт эхлэв. Зүүн талаас ойгүй, эгц өндөр толгод залгаж, баруун талын, хамгийн өндөр, чулуурхаг толгой бусдаасаа холд сүндэрлэж, мохоо оргил нь эргэлдэж байгаа мэт харагдав.

- Энэ бол Эргүүлэг – гэж Тэнэмэл хэлээд – эртний зам энэ уулын бэлээр өнгөрдөг юм. Бид зүүн талаар нь тойрсон. Маргааш үд дунд тэнд хүрээд орой дээр нь гарна. Гарахаас өөр аргагүй гэв.

- Яагаад? – гэж Фродо асуухад:

- Бидний зам шалгагдсан, хаашаа ч гарах аргагүй... Харин тэнд юу хүлээж байгаа нь тодорхойгүй. Гэхдээ уулан дээрээс Их зам сайн харагддаг юм.

- Чи тэнд Гэндальфтай уулзаж магадгүй гэж байсан шүү дээ.

- Тийм ээ, гэхдээ одоо тийм найдвар бага байна. Тэр энэ замаар явлаа ч гэсэн Уулын сууринг тойрох учир бидний тухай мэдэхгүй. Яг нэг зэрэг тэнд хүрэх нь юу л бол. Хэрэв яг тааралдахгүй бол зөрнө, тэр ч биднийг хүлээж болохгүй, бид ч түүнийг хүлээж болохгүй. Морьтнууд биднийг ойд барьж авч чадаагүй болохоор заавар Эргүүлэг дээр гарна, тэндээс бүх юм ил харагддаг. Одоо бид энд зогсч байна, биднийг янз бүрийн араатан, шувууд харж л байгаа...

Хоббитууд алсын толгодыг сэтгэл түгшин харж, Сэм цонхигор тэнгэрийг ажиглаж, тэндээс бүргэд юм уу элээ гараад ирэхийг хүлээх мэт зогсов.

- Чи ч их найдвар төрүүлж байна даа Тэнэмэл – гэж тэр толгой сэгсрэв.

- Тийм байна уу? – гэж Фродо асуухад:

- Тийм байна - гэж Тэнэмэл бодлогошронгуй, дургүйхэн хариулаад - Өрөм хугалдаг толгой руу ой дундуур шууд яваад Эргүүлэг хүрье. Тэнд хойд талаас орж ирсэн жим бий. Дайрах ёстой юмыг тойрох аргагүй гэв.

Тэд бүтэн өдөржин бараг амралгүй яваад л байлаа, яваад л байлаа. Намарэртийн хүйтэн үдэш хамаг хувцсыг нь чийг даалгана. Гэвч хөл дор бага зэрэг хуурай болж, ар талд манан өтгөрсөөр байв. Нүдэнд үл үзэгдэх шувууд жаргах улаан нарыг үдэж уйлан дуулах мэт жиргэнэ. Хоббитууд тэртээ алсад хоцорсон Ууган хясааны дугариг цонхны цаадах амгалан үдшийг сэтгэл гэгэлзэн саналаа.

Нар шингэхэд тэд толгодын дундуур сүлжсээр намаг дундуур ороод сураггүй болсон голын эрэгт хүрч харанхуй болохоос өмнө амжиж эргийн дагуу алхав. Тэгээд голын эрэг дээрх хөгшин модны дэргэд хоноглохоор зогсов. Бүдэг саарал тэнгэрийн дорх уйтгартай нүцгэн уулс тэдний дээрээс өнгийнө. Хоббитууд ээлжээр харуулд гарч, Тэнэмэл огт унтсангүй. Сар жижгэрч, шөнө дундаас хойш хүйтэн саарал гэгээ орчныг гийгүүлэв.

Өглөөн нарны түрүүчийн туяатай зэрэгцэн хөдөллөө. Агаар хүйтэн, тэнгэр цайвар цэнхэр. Хагас нойртой хоносон боловч хоббитуудын бие амарчээ. Тэд урт аян, хомс хоолонд аль хэдийн дасчээ. Бараг хоол идэхгүйгээр яваад байсан гэвэл Хоббитанд хэн ч итгэхгүй биз ээ. Фродо бараг хоёр дахин сайхан зантай болсон гэж Пин хэлж билээ.

- Юуны чинь сайхан зантай болох – гэж Фродо бүсэндээ шинэ нүх гаргах зуураа санаа алдаад – надаас бараг юу ч үлдсэнгүй. Хэрэв цаашдаа ийм маягаар яваад байх юм бол би хий үзэгдэл болох байх гэв.

- Үгээ олж яриарай – гэж Тэнэмэл тэдний яриаг гэнэт эрсхэн таслав.

Уулс итгэл муутай дүнсийн заримдаа мянга гаруй фут өндөрсөн тэдэн рүү ойртож, заримдаа холдож, аянчдыг гуу жалга хэсүүлэн дорно зүг рүү дөхүүлнэ. Хаа сайгүй өвсөнд хучигдсан эртний хана, далангийн үлдэгдэл цухуйж, хааяа эртний чулуун байгууламж үзэгдэнэ. Харанхуйд тэд уулын баруун бэлд хүрч хоноглов. Аравдугаар сарын тавны шөнө болж, тэд Уулын суурингаас гарснаас хойш зургаан хоног өнгөрчээ.

Өглөө нь аль эрт үзэгдэхээс байсан жим ид шидээр юм шиг гараад ирэв. Тэд жимээр баруун тийш эргэж, өмнө зүг явлаа. Жим их зальтай байв. Тэр уулан дээрээс харуулдагчдаас болон доороос ажиглагчдаас адилхан нуугдаж чадсан байлаа. Гуу жалга руу шургаж, довцог толгодын цаагуур нуугдан, том том хаднуудын хоорондуур сүлжиж, аянчдыг найдвартай өндөр хана мэт хамгаалж байлаа.

- Энэ жимийг хэн гаргасан юм бол, надад нэг л таалагдахгүй байна. Нойтон Жалгыг л санагдуулаад байна, Эргүүлэгт булш байдаг уу? – гэж Мерри ээлжит чулуун гарц руу орох үед асуув.

- Байхгүй, дунаданчууд өрөм хугалдаг толгодод амьдардаггүй байсан, зөвхөн Ангмарын илбэчид, шидтэнгүүдийн довтолгооноос л энд хамгаалдаг байсан юм. Дараа нь энэ жимийг уулын оргилд нууцаар гарах зорилгоор гаргасан. Нэгэн цагт Эргүүлэг дээр Амон - Сул буюу нийтийн хэлээр Салхин уулын цамхаг гэдэг харуулын цамхаг байсан. Дайснууд тэр цамхгийг оргүй болтол шатааж, зөвхөн эртний уулсын дээр байдаг титэм шиг чулуун хүрээ л үлдсэн. Уг нь их өндөр, бахархам сайхан цамхаг байсан даа. Сүүлчийн холбооны өдрүүдэд цамхаг дээр Элендил өөрийн биеэр ирж, Гил-Гэладыг хүлээн зогсч байсан юм.

Хоббитууд Тэнэмэлийг итгэлгүйхэн харав. Тэр нууц замуудыг төдийгүй бас эртний түүхийг мэддэг байх нь ээ!?

- Гил-Гэлад гэж хэн юм бэ? – гэж Мерри асуусан боловч Тэнэмэл хариулсангүй. Тэр бодолд умбажээ. Тэгтэл Сэм намуухан хоолойгоор:

Гил-Гэлад –гэгээн хаан

Нийт Эльфийн эцсийн хаан

Дэлхийг нөмөрсөн хар шөнийг

Дийлж дарахыг хүсчээ.

Харанхуйд бамбай нь нар шиг туяарч

Хар илднүүдийг тасар татан

Хар хясааны дундуур гэрэлт илд нь

Харвах цахилгаан мэт гялалзана.

Харанхуйг сарниаж чадсан ч

Хаан Гил-Гэлад ялж чадаагүй

Харин түүний од тэнгэрийн чанад

Харваж үүрд байхгүй болсон.

Бүгд Сэм рүү гайхан эргэж харав.

“Цааш нь”- гэж Мерри гуйв.

- Цааш нь мартчихжээ – гэж Сэм хариулаад – би бүр бага байхдаа ноён Бильбогоос сонссон юм. Би эльфүүд гэхээр л бараг ухаан алдчихдаг байсан болохоор тэр надад дандаа тэдний тухай ярьж өгдөг байсан. Тэр надад бичиг заасан, өөрийнхөө зохиосон үй олон шүлгийг уншиж өгдөг байсан юм.

- Тэр үүнийг өөрөө зохиогоогүй – гэж Тэнэмэл хэлээд – энэ бол “Гил-Гэладын мөхлийн дуу” гэдэг хуучны дууллын эхлэл, Бильбо зүгээр л түүний эльф хэлнээс орчуулсан байна.

- Цааш нь Мордорын тухай зөндөө юм байсан, би айсандаа болоод цээжлээгүй юм. Өөрөө тийшээ явах юм гэж яаж санах вэ дээ.

- Гэвч одоохондоо Мордор руу яваагүй байна – гэж Пин хэлэхэд:

- Чимээгүй, энэ үгээс болгоомжил – гэж Тэнэмэл түүнийг ёвров.

Тэд жимийн өмнөд үзүүрт тулж очиход өмнө нь аравдугаар сарын нарны төдий л хурц биш тунгалаг гэрэлд уулын хойд хажуу руу тойрсон ногоон саарал далан байхыг харав. Уулан дээр даруйхан гарахаар шийдэцгээв. Одоо нуугдаад яах билээ, эргэн тойронд хэн ч байхгүй. Анд нөхөд ч байхгүй, дайсан ч байхгүй гэсэн ганц найдвар л үлдсэн байлаа. Уулын хажууд юу ч алга харагдана. Хэрэв Гэндалф энд ирсэн бол ямар ч ул мөр үлдээгээгүй бололтой.

Эргүүлгийн баруун хажууд үзэгдэхгүй байсан жалга байх бөгөөд ёроол нь өтгөн өвс ургасан хуурай голдрил байв. Тэнд Сэм, Пин хоёрыг пони болон бүх ачаатайгаа орхилоо. Тэгээд дээш авирч цаг орчмын дараа Тэнэмэл оргил дээр гарлаа.

Фродо, Мерри хоёр хадан цохионуудыг дараалан давж түүний араас байдаг хүчээрээ урагшилж байв.

Эргүүлэг дээр гараад тэр хоёр Тэнэмэлийн ярьсан цамхгийн буурин дээрх эртний чулуун тойргийг үзэв. Хавтгай оройн тэг дунд чандмалан тавьсан чулуунууд дээр саяхан гал түлсний тэмдэг чулуунууд тортогтон харласан байв. Чулуунуудыг тойрсон газрын ургамал шатсан байх бөгөөд эргэн тойронд амьтай юм юу ч байхгүй мэт нам гүм байв.

Эртний уулын оргил дээрээс эргэн тойронд цэлийх уудам алсыг халиахад нэг л янзын хоосон тал, өмнө зүгт хааяа нэг сийрэгхэн төгөл үзэгдэж, ус гялтайж харагдана. Өмнө талаас эртний их зам сайн харагдаж байсан бөгөөд баруунаас наашлан дов толгод, хонхор хотгорууд дундуур могойчлон мурилзсаар зүүн талын хар толгодын цаагуур далд оржээ. Яаж ч харсан Их зам дээр амьд юмны дүрс алга байв. Цааш харахад Манант уулын хар хүрэн цавчлууд, тэдгээрийн цаана өндөр өндөр саарал уулс, тэгээд үүлэнд умбасан цаст оргилууд үзэгдэнэ.

- За энэ дээ. Яах гэж ийшээ яарсан юм бол? Мод ч байхгүй, горхи булаг ч байхгүй, нуугдах газар ч байхгүй. Гэндалф ч мэдээж байхгүй, тэр энд ирээд юугаа хийх билээ – гэж Мерри урамгүй өгүүлэв.

- Тийм ээ, түүнд энд хийх юм байхгүй – гэж Тэнэмэл бодлогошронгуй зөвшөөрөөд – Гэхдээ тэр Уулын сууринд биднээс хойш хоёр хоногийн дараа очсон ч биднээс түрүүлж ирээд хүлээж чадах л байсан гэв.

Тэр гэнэт тонгойж, тортог болсон чулуунууд дундах гал огт хүрээгүй хавтгай цагаан чулууг ажиглав. Дараа нь тэр чулууг авч эргүүлж тойруулан үзээд:

- Хар даа, чинийхээр бол энэ юу вэ? – гэж Фродогоос асуув.

Чулуун дээр хэд хэдэн гүн зураас байхыг Фродоо харлаа.

- Дөрвөн зураас, хоёр цэг – гэж тэр хэлэв.

- Яг ч тийм биш ээ – гээд Тэнэмэл инээмсэглэж – зүүн талын тэмдэг нь рун бичгийн Г үсэгтэй адилхан байна. Гэндалфын мэдээ байж болох юм, гэхдээ заавал мөн байх албагүй, мөрдөгчид ч рун бичгээр бичдэг, энд цөөнгүй л ирдэг юм.

- Хэрэв Гэндалф үлдээсэн бол ямар учиртай байх вэ? – гэж Мерри асуув.

- “Г”- гурав, - “аравдугаар сарын гурванд энд Гэндалф ирсэн” – гэж Тэнэмэл хариулаад – гурав хоногийн өмнө гэсэн үг. Бас их яарч бичсэн байна, тодорхой бичиж амжсангүй, аюул их ойрхон байж. Тэгвэл ч бид хэцүүднэ дээ.

- Тийм байж, гэлээ ч гэсэн тэр энд ирсэн бол сайн хэрэг – гэж Фродо хэлээд – жаахан тайван байж тэр энд, хойно ч юм уу, урд маань байгаа эсэхийг мэдэх сэн.

- Тийм ээ, тэр энд байсан, түүн рүү дайрсан гэдэгт би итгэлтэй байна, чулуун дээгүүр гал яаж гүйснийг харж байна уу? Дорно зүгт гэрэл анивалзаад байсныг санаж байна уу? Яг гурав хоногийн өмнө шүү дээ. Түүнийг энд бүсэлж аваад гэнэт дайрсан байна, чухам яаж дууссаныг бүү мэд. Товчхондоо, тэр энд алга, тиймээс бид өөрсдөө л Уудам хөндий орох хэрэгтэй боллоо доо.

- Уудам хөндий хүртэл хол уу? – гэж Мерри нүд гүйцэхгүй алсыг ядарсан нүдээрээ халиан байж асуув. Эргүүлэг дээрээс даанч дэндүү том юм шиг хоббитуудад санагдаж байлаа. Тэртээ доор Их зам төгсгөлгүй урт нарийхан тууз мэт хөвөрч байлаа.

- Лигээр хэмжээгүй – гэж тэнэмэл хариулаад – цаг агаар сайхан байхад би бол Даргилаа голын Бруины гарам хүртэл найм хоног явдаг юм, бид бол арван дөрөв хоногоос наашгүй гэв.

- Хоёр долоо хоног, юу ч тохиолдож болно гэж Фродо хэлэв.

Юу ч - гэж Тэнэмэл баталлаа.

Тэд оргилын өмнөд зах дээр зогсч байсан бөгөөд Фродо амьдралдаа айж үзээгүй ихээр айж байгаага мэдрэв. Ер нь юу болоод байгаа юм бэ? Энх амгалан, баяр баясгалантай Хоббитандаа байгаад байж яагаад болоогүй юм бэ?- гэж Фродо бодлоо. Тэр хараал идсэн Их замаас баруун тийш эх нутгийнхаа зүг харлаа. Тэгээд их замаар хоёр хар цэг удаан мөлхөж байгааг, бас зүүн талаас гурван хар цэг урдаас нь мөлхөж байгааг үзэв.

- Хараач!- гэж тэр доош заан хэлэхэд Тэнэмэл чулуун шүдний араар навгасхийн хэвтээд, Фродог татаж унагалаа. Араас нь Мерри унаад өгөв.

- Юу болов?- гэж Мерри шивнэн асуухад Тэнэмэл:

- Одоохондоо мэдэхгүй байна, муу юм болно гэж бод гэлээ.

Тэд оргилын зах руу мөлхөж, чулуунуудын ард нуугдан дахин доош харав. Өглөөний туяа бүүдгэрч, дорно зүгээс үүл наашилж байлаа. Таван өчүүхэн хар цэгээс айгаад байх юм байхгүй мэт боловч Фродо, Мерри хоёр Эргүүлэг уулнаас холгүй Их зам дээр хар морьтнууд цугларч байгааг шууд арьс махаараа мэдэрлээ.

- Тийм ээ, тэд нар байна, дайсан хажууд байна! – гэж хоббитуудаас хамаагүй хурц нүдтэй Тэнэмэл хэлэв.

Тэд хамгийн ойрын хонхор болон түүний дэргэдэх налуууг ажиглав. Булгийн хавийн газарт өвс гишгэгдсэн, гал түлсэн ором, хэн нэгний яаран буудалласан ул мөр байна. Хонхорын захад хэсэг хуурай мөчир бөөгнөрүүлсэн байхыг Сэм олов.

- Үүнийг өвгөн Гэндальф бөөгнүүлсэн байх, тэр биш ч байж болно, гэхдээ энд эргэж ирнэ гэж тооцоолсон байна – гэж Сэм Пинд өгүүлэв.

- Би чинь юу болж байна аа, би өөрөө юуны өмнө энд юм бүхнийг шалгасан байх ёстой шүү дээ – гэж Тэнэмэл хэлээд булаг руу яаран очлоо.

- Өнгөрчээ, Сэм Пин хоёр бүгдийг гишгэлж амжсан байна. Мөрдөгчид нэлээд эрт түлш базаасан байна, гэхдээ шинэхэн мөр байна, хэд хэдэн хос мөр... гэж Тэнэмэл булаг дээрээс ирээд ямар нэг шийдвэр гаргаж байгаа бололтой бодолхийлэн суув.

Хоббитууд урт цув, том гуталтай хар морьтнуудыг саналаа. Хэрэв тэд энэ хонхрыг тандсан бол эндээс даруйхан холдох хэрэгтэй байлаа. Сэм эргэн тойрноо түгшүүртэй харлаа. Дайсан ойрхон, нэг хоёр бээрийн зайтай байна, гэтэл Пин бид хоёр эргэн тойронд хамаагүй гүйж байдаг!

- Ноён Тэнэмэл, эндээс зайлцгаая – гэж тэр гуйх аястай хэлээд – цаг оройтож байна, энэ хонхрын байдал нэг л сэжигтэй байна – гэв.

- Тийм ээ, хонхор найдваргүй байна – гээд Тэнэмэл тэнгэр рүү харж цагийн баримжаа аваад – гэхдээ Сэм минь надад ч гэсэн энд таалагдахгүй байгаа боловч эндээ байсан нь дээр. Шөнө болтол бид үүнээс дээр газар олохгүй. Наанадаж бид бусдын нүднээс далд байна. Тэдний тагнуулууд хаа сайгүй шиншилж байгаа. Бид Их замыг хөндлөн гарах хэрэгтэй, гэтэл Их зам дайсны хараанд байгаа. Их замын цаана хоосон талаас өөр юу ч байхгүй гэв.

- Морьтнууд чинь хараагүй шүү дээ. Өдрийн гэрэлд тэд үнэрээр баримжаалж явдаг. Гэтэл чи биднийг уулын оргил дээр гаргачихаад одоо “дайсан харчихна” гээд байх юм, нэг л ойлгомжгүй байна даа – гэж Мерри хэлэв.

- Оргил дээр би тун ч болгоомжгүй байсан, би Гэндальфаас ямар нэг мэдээ байна уу гээд л хайгаад байсан, бид гурав удаан ил байсан. Морьтнууд хараагүй нь үнэн боловч хар морьд нь хардаг, эргэн тойрон газарт ч, тэнгэрт ч дайсны тагнуулууд, жижиг гар хөл, хэл ам бологчид нь хөлхөлдөж байгаа. Уулын сууринд хичнээн байсныг санаж байна уу? Морьтнууд ертөнцийг өөрийнхөөрөө таньж мэддэг. Өдөр тэд бидний сүүдрийг үздэг, харанхуйд тэд бидний огт мэдэхгүй байгалийн нууц хар бичээсийг уншдаг юм. Тэд халуун цусыг цаг үргэлж мэдэрч, шунаж, өшин хорсч байдаг юм. Үнэрлэх, харах мэдрэхүйгээс өөр мэдрэхүй тэдэнд байдаг. Бид тэднийг энд байна гэж мэдэрч байна, гэтэл тэд биднээс арав дахин хурц мэдэрдэг. Түүнээс гадна тэднийг бөгж татаж байгаа.

- Ямар ч аврал байхгүй гэж үү?- хэмээн Фродо дуу алдан хэлээд эргэн тойрноо айсан нүдээр харж – байрнаасаа хөдөлбөл дайсан үзээд барьж авна, байрнаасаа хөдлөхгүй байвал үнэрлэж мэдрээд олчихно! гэхэд Тэнэмэл:

- Хүлээж бай, санаагаар унах хэрэггүй – гээд мөрөн дээр нь гараа тавьж - Чи ганцаараа биш, эхлээд энэ хуурай модыг асаая. Гал биднийг хамгаална. Саурон галыг гараараа барьдаг, тэр юм бүхнийг барьж үздэг юм, гэвч хар морьтнууд галаас айдаг, гал бол бидний анд нөхөр гэв.

- Сайн байна, найз минь гэж Сэм бувтнаад – бид түүдэг гал асаачихъя, тэгээд эндээ сууж, нааш нь битгий оруулаарай гэж хашгирах л үлдэх шив- гэлээ.

Тэд хонхрын ёроолд эвтэйхэн газар олоод гал түлж, хоол ундаа хийлээ. Үдшийн сүүдэр өтгөрч, хүйтэрлээ. Тэд өглөөнөөс хойш юу ч идээгүй тул араатан мэт өлсөцгөөж байвч хоол нь аргагүйн эрхэнд дэндүү даруухан байв. Өмнө нь араатан, шувуудын эзэмшил болсон уйтгартай, эзэнгүй хоосон тал цэлийж байв. Тэнд зөвхөн хааяа нэг мөрдөгчид л явж өнгөрдөг. Өөр аянчид тун ховор, аянчид гэж ч юу байхав, жишээ нь тролли нар Манант уулын умард нугачаануудаас хааяа үүгээр өнгөрдөг. Аянчид зөвхөн Их замаар явах бөгөөд голдуу гномууд өөрийнхөө хэргээр яаран явж өнгөрдөг, харийнхантай үг сольдоггүй билээ.

- Одоо хоол хүрэлцэхгүй боллоо. Сүүлийн хоёр өдөр бид тун бага идсэн ч гэсэн урьд нь илүү идэж байсан байна, одоо багаар бодоход хоёр долоо хоног явах болно гэж Фродо хэлэхэд:

- Ой биднийг тэжээнэ. Жимс, үндэс, өвс иднэ, аягүй бол шувуу ч агнана. Хоол хүрэлцэнэ. Бүсээ чангалаад алхаад байхад Элрондагаар дайлуулна гэж найдацгаа! – гэж Тэнэмэл тайвшруулав.

Хонхорт юу ч харагдахгүй, зөвхөн бөөгнөрсөн саарал бүрэнхий л байна. Тэнгэр цэлмэж, одод чимээгүйхэн гялалзав. Фродо болон бусад хоббитууд байгаа бүхнээрээ хучаад гал руу шахцалдан, ганц Тэнэмэл уранхай цуваа нөмрөөд холхон сууж гаансаа сорон бодолдоо автжээ. Шөнө болж гал хурцаар дүрэлзэн Тэнэмэл хоббитуудын айдсыг хөөхийн тулд үлгэр, тууль ярьж өгөв. Тэр өнө эртний олон домог, түүх мэднэ, эльфүүдийнхийг ч мэднэ, хүмүүсийнхийг ч мэднэ. “Энэ хүн хэдэн настай юм бол, яаж ийм их юм мэддэг байна аа?” гэж хоббитууд гайхаж байв. Эртний эльфийн хаадын тухай тууж ярьж дууссаны дараа Мерри:

- Гил-Гэладын тухай ярьж өгөөч, жишээ нь “Гил-Гэладын мөхлийн дуу” байна. Чи мэднэ шүү дээ – гэж гуйлаа.

- Мэдэлгүй яах билээ, Фродо ч бас мэднэ. Эртний энэ түүх түүнд шууд хамаатай.

Мерри, Пин хоёр Фродо руу харахад цаадах нь гал руу ширтэж суулаа.

- Үгүй ээ, би тун бага, зөвхөн Гэндальфын ярьж өгснийг л мэднэ – гэж Фродо бодолхийлэн хэлээд – Гил – Гэлад бол Дундад газрын эльфүүдийн хүчирхэг хаадын сүүлчийнх нь гэж мэднэ. Гил-Гэлад гэдэг нь эльф хэлээр “оддын гэрэл” гэсэн үг. Тэр эльфүүдийн анд дайчин Элендилтэй хамт их аян дайнд... гээд ярьж эхэлтэл Тэнэмэл:

- Болно оо, Дайсны гар хөлүүд ойрхон шиншилж явахад энэ тухай ярих хэрэггүй байх. Элрондын цайзад очоод энэ туужийг дуустал нь сонсоцгоогоорой – гэв.

Тэгвэл тэр үеийн тухай юу ч юм ярь л даа, эльфүүд тэр үед ямар байсан бэ? Ийм аймаар

харанхуйд эльфүүдийн тухай сонсоход юу нь муу байх билээ – гэж Сэм шалгаав.

- Тинувиэлийн тухай ярьж өгье – гэж Тэнэмэл зөвшөөрөөд – товчилж ярья. Учир нь энэ домог маш урт, төгсгөлийг нь Элрондагаас өөр хэн ч мэдэхгүй, тэр ч байтугай ер нь төгсгөл байсан эсэхийг ч мэдэхгүй. Их сайхан тууж, даанч Дундад газрын бүх домгийн адил гунигтай. Гэлээ ч гэсэн сэтгэл чинь гэгээрэх байх.

Тэр жаахан бодосхийж эхлэлийг нь санаад ярих биш аяархан дуулав:

Уудам талын шүүдрэн нөмрөг дээгүүр

Уулын нугын сэрүүн тунгалаг дундуур

Ургаж тэнгэр өөд тэмүүлсэн

Ухаан мансуурам анхилуун цэцэгс.

Шөнийн нам гүмд Лучиэнь

өглөөний будан мэт гэгээн.

Алтан чавхдас доргион эгшиглэхүй

Аялгуут бүжгэндээ мөнгөрөн байв.

Мөсөн цагаан малгайт

Манант уулсаас нэгэнтээ

Ноорсон аянчин ирээд

Нойрмог үүлсийн доор

Очис цацан гэрэлтэх

Ой руу харцаа шиджээ.

Хээлэн хөврөх үүлсийн завсраар

Хээтэн хөөсрөх горхисын дээгүүр

Хүмүүн дүрд хувилсан

Хий туяа үзэгджээ.

Аянчин тэр нь Берен байжээ,

Аз жаргалд хөтлөх жим

Алтрах ойд нээгдэх шиг болжээ.

Үнэн байдал, үзэгдэх зүүд сүлэлдсэн

Үй түмэн сүүдэр дундуур

Үзэгдэх төдий туяаны өөдөөс

Үүрсэн ачаагаа мартаж орхиод

өмнө зүг рүү аянчин тэмүүлжээ.

Харин Лучиэнь охин тэрхэн хоромд

Харвах туяа мэт алга болжээ.

Харанхуй нуга, өндөр бутнууд,

Харлах ой, цайрах саран өмнө нь тулжээ...

Түүнээс хойш хавар болох бүрт

Тэнхээт, анхилуун, мансуурам

Тэр бут цэцэглэх цагаар

Цэцэгсийн дээгүүр манан хуйларч

Цэнгэн бүжихийг үздэг болжээ...

Гэтэл удалгүй Лучиэний дуу

Газар дээгүүр шувуу шиг нисч

Хаврын өдрийг сэрээдэг болжээ.

Шөнийн харанхуйг арчих

өглөө эртийн нарнаар

Гал шингээсэн навчсаараа

Тал хөндий алтардаг болжээ.

Шүүдэрт өглөөн нам гүмд

Түүнийг ердөө хараагүй ч

Тэр аянчин тэвчээр алдаж:

Тинувиэль! – гэж хашгирчээ-

Тэгтэл ойн цуурай

Тэртээ алсыг нэлд нь доргион

Тэр гайхамшигт Эльф нэрийг

“Алтан гургалдай” хэмээн орчуулжээ.

Түүнийг сонсоод Тинувиэль охин

Хаврын шувуудын жиргээн мэт

Харзлах горхины шулганаан мэт

Тэнгэрлэг дуу бүжгээ

Тэр дор нь зогсоожээ:

Үхэлгүй мөнх дагинасын нэр

Үүрдийн эх нутгийнхаа нэр адил,

Үхэлт амьтдыг өөр ертөнцөд илгээгч

Үйлийн үргүй цэвэр долгион мэт

Үгээр нэрлэж болдоггүй учир

Хувь заяа өөрөө түүнийг

Хаврын мөнгөлөг цуурайгаар

Бэлэг болгож Беренд өгсөн,

Үхэлт хүмүүнтэй үүрд холбоод

Үхлийн дараа жаргал өгөх

Үйлийн үрийг дагахаар шийджээ.

Тэнэмэл санаа алдаад хэсэг дуугүй сууснаа:

- Үнэндээ энэ бол үлгэр биш, дуу байгаа юм. Эльфүүд ийм дуун үлгэрээ “эннсэннат” гэдэг юм. Манай хэлээр сонсогддоггүй, зүгээр л алсын үггүй цуурай л сонсогдоно. Бараирын хүү

Берен Лучиэнь Тинувиэльтэй учирсан гэдэг. Берен жирийн үхэлт хүмүүн, Лучиэнь бол Дундад газрын хамгийн эртний, хамгийн залуу эринд эльфүүдийн хаан байсан Тинголын охин. Бүр тэр сайхан залуу эринд ч түүнээс сайхан нь үгүй байжээ. Түүний гоо үзэсгэлэн Умард хязгаарын манангийн цаадах оддын гэрлээс ч тод, нүүр царай энхрий уяхан гэрэл цацруулдаг байсан гэдэг. Тэр цагт Бүх нийтийн дайсан умард газар Ангбэндийг захирдаг байсан, Саурон ердөө л түүний зарц байсан, өрнийн эльфүүд Бүх нийтийн дайсны хулгайлсан Сильмариллын шидэт очир эрдэнийг байлдан авахаар Дундад газарт ирсэн, хүмүүний өвөг дээдэс ч эльфүүдтэй холбоотон байжээ. Гэвч Дайсан ялж, Бараир тулалдаанд амь үрэгдэж, Берен азаар аврагдаж, үхлийн аюулаас үл эмээн их уулсыг давж, Нелдоретийн ой дахь Тинголын нууц улсад ирсэн. Тэнд Лучиэнийг харж, дууг нь сонсчээ. Лучиэнь Эсгальдуины шидэт голын дэргэд ойн цоорхойд бүжиглэж, дуулж байжээ.

Тэгээд түүнийг Тинувиэль гэж нэрлэсэн, хуучны хэлээр алтан гургалдай гэсэн үг. Тэр хоёр хожим нь их зовлон үзсэн, удаан хугацаагаар хагацсан. Тинувиэль түүнийг Сауроны мөсөн шоронгоос гаргаж авсан, хамтдаа олон аймшигт сорилтыг баяртай давсан, Дайсны хааныг ширээнээс нь авч хаяад ертөнцийн бүх очир эрдэнээс хамгийн тунгалаг нь болсон гурван сильмарилл бүхий төмөр титмийг салгаж авсан, нэгийг нь Лучиэний эцэг Тинголд хуримын сүй болгож өгсөн. Гэвч дараа нь Ангбэндийн хаалганаас дайрсан Чонондолоохойг Берен дийлээгүй, Тинувиэлийн гар дээр өөд болсон, Тинувиэль нөгөө ертөнцөд түүнтэй хамт байхын тулд үхлийг сонгосон гэдэг. Дуун үлгэрт итгэх юм бол, тэр хоёр тэр ертөнцөд уулзаад тэндхийн цэцэрлэгт нугаар хөтлөлцөн зугаалж явдаг гэсэн. Бүх эльфүүдээс ганцхан Лучиэнь Тинувиэль энэ ертөнцийг орхисон, мөнх амьдардаг эльфүүд хамгийн хайртай нэгийгээ ингэж алдсан гэдэг юм. Тэр л хүмүүсийг эртний эзэн эльфүүдтэй холбож өгсөн юм. Лучиэний удам одоо ч байдаг, тэд их сайн явах болно гэж эртний мэргэн домогт урьдчилан хэлсэн байдаг. Уудам хөндийн Элронд бол тэдний удам. Берен, Лучиэни хоёроос Тинголын угсаа залгамжлагч Диор төрсөн, түүний охин Гэрэлт Эдвин Тэндэхийн далай руу хөлөг онгоцоор аялж манай ертөнцийн манан дундаас Сильмираллтай титмээ гялалзуулан гарч ирсэн Эарендилтэй гэрлэсэн. Эарендилийн хүү нь манай баруун хязгаарын хаан Нуменор.

Тэнэмэлийг ярьж байх зуур хоббитууд түүдэг галын гэрэлд бүдэгхэн тодорч байгаа түүний нэг л хачин бардам царайг нүд салгалгүй харж байв. Нүд нь гялалзаж, дуу хоолой нь гайхалтай, тод сонсдоно. Толгой дээр нь одод яралзсан бараан тэнгэр дүнсийнэ. Гэнэт Эргүүлгийн оргилд цайвар гэрэл гийлээ. Бүтэн саран бараан уулан дээгүүр удаанаар мөлхөж, одод түүний гэрэлд бүдгэрэв. Яриа дуусч, хоббитууд суниаж биеийн чилээгээ гаргав.

- Хараач, сар гарчихлаа, оройтож байна – гэж Мерри хэлэв.

Бүгд дээш харахад сарны гэрэлд уулын оргил дээр жижиг хар юм тод харагдав. Сарны гэрэлд том чулуу тодорч харагдав бололтой.

Хүйтэн байсан тул Сэм, Мерри хоёр түлээ авчрахаар явлаа. Чимээгүй, нам тайван мэт боловч Фродо гэнэт мөс мэт хүйтэн айдас төрж, гал руу яаран дөхөв. Сэм дээрээс гүйж ирлээ.

- Хэн ч алга байх шиг, тэгсэн мөртөө би нэг юмнаас айгаад байна. Хонхроос хаашаа ч хөдлөхгүй. Бидэн рүү гэтээд байх шиг байна уу даа?

- Чи хэн нэгнийг хараагүй биз? – гээд Фродо ухасхийн босов.

- Үгүй ээ эзэн минь, хэнийг ч үзээгүй, ер нь хараа ч үгүй.

- Би үзсэн, хоёр юм уу гурван хар сүүдэр, наашаа мөлхөөд ирэхгүй байгаа? – гэж Мерри хэлэв.

- Түүдэг гал руу ойрт, гал руу нуруугаа харуул! – гэж Тэнэмэл тушаагаад – хуурай, урт мөчир авцгаа гэлээ.

Чимээгүй харанхуй руу ширтэж, дуугаралгүй чагнан сууцгаав. Ямар ч чимээгүй, Фродо чимээгүйн дарамтаас салахын тулд байдаг хоолойгоороо хашгирмаар санагдав...

- Чимээгүй! – гэж Тэнэмэл шивнэтэл Пин:

- Энэ юу вэ? энэ юу вэ гэж амьсгаа давчуу шивнэв.

Төдөлгүй хонхрын ирмэгээр нэг, хоёр, гурван хар сүүдэр гарч ирэхийг үзэх биш мэдэрлээ... Гурав биш бүр дөрвөн сүүдгэр дүрс харанхуйн хар цоорхой мэт дээр нь зогсч байна. Могой шиг исгэрэх сонсдож, булшны хүйт мэдрэгдэж байв. Тэгснээ сүүдрүүд хөдөлж, ойртлоо.

Пин, Мерри хоёр айсандаа түрүүлгээ харан нам хэвтэв. Сэм эзнийхээ дэргэд суулаа. Фродо тэсэхийн аргагүй мөсөн айдаст авгаж... зөвхөн бөгжөө зүүх хэрэгтэй гэж гэнэт бодов. Тэр булшны толгодыг мартаагүй, Гэндальфын захиасыг мартаагүй боловч эсэргүүцэх хүч байсангүй. Хэл нь ч гацчихав. Сэм эзэн рүүгээ айн ширвээдсэн нүдээр ширтэнэ, эзэндээ туслах арга байдаггүй, яагаад ч байдаггүй. Фродо нүдээ аньж тэсэхийг оролдсон боловч чадсангүй... гинжээ татаж, бөгжөө тэмтэрч үзээд зүүн гарынхаа долоовор хуруунд удаан углав.

Харанхуйд бүх юм хэвээр байсан боловч хар сүүдэрнүүд гэнэт урагшлан ирж тод харагдав. Тэдний өмнө саарал цувтай таван өндөр дайчин зогсч байлаа. Хоёр нь толгойн орой дээр үлдэж, гурав нь наашлав. Тэдний хонхойсон нүдний аяга хайр найргүй хэрцгий, хурц харцаар шөвөгдөх мэт, буурал толгой дээр нь мөнгөн дуулга, гарт нь ган илд. Тэд Фродо руу мөсөн харцаараа шөвөгдөн урагш дахин нэг алхав. Фродо кинжаалаа сугалахад кинжаал улайсгасан мэт час улаан болов. Хоёр нь нам зогсч, гурав дахь нь Фродо руу дайрав. Тэр бусдаасаа өндөр, дуулга нь титэмтэй байлаа. Нэг гартаа урт илд, нөгөөдөө кинжаал барьсан, кинжаалын нь ирнээс үхэнгэ хүйтэн гэрэл цацарна.

Фродо түрүүлгээ харан унаад яагаад тэгснээ өөрөө ч мэдэлгүй “О Элберет! Гилтониэль!” – хэмээн хашгираад дайран ирсэн дайсны хөл рүү кинжаалаа дүрж орхив. Хилэгнэн орилох дуун харанхуйг цочоож, үхэл тээгч мөс шиг хүйтэн төмөр Фродогийн мөр рүү шигдэн оров. Харанхуйгаас хоёр гартаа бамбар барьсан Тэнэмэл дүүлэн гарч ирж байгааг хараад тэр ухаан алдлаа. Сүүлчийн хүчээ шавхан бөгжийг хуруунаасаа аваад кинжаалаа алдан газар тэвэрч уналаа.

Бүлэг 12

Эртний их замаар

Фродо ухаан ороход бөгжөө үхсэн ч тавихгүйгээр тас атгаснаа мэдэв. Тэр өндөрт дүрэлзэн асч байгаа түүдэг галын дэргэд хэвтэж байх бөгөөд айж түгшсэн Сэм, Пин, Мерри гурвын царай дээрээс нь тонгойж байгааг харав.

- Юу болсон бэ? Үхсэн ноён хаана байна? – гэж хөшингө хэлээ арайхийн хөдөлгөж асуув.

Хариу хэлсэнгүй. Баярласандаа гурвуулаа багтрах шахаж, бас дээр нь асуулт ойлгомжгүй байв. Дараа нь Сэм ярихдаа хаанаас ч гараад ирснийг бүү мэд аймшигт сүүдрүүд дайрсан, Фродо гэнэт алга болсон, Сэмийг түлхээд унагачихсан, эзнийх нь дуу хаа нэгтээ холын холоос юм уу, бүр газар дороос сонсогдсон, ямар нэг огт ойлгомжгүй юм хашгираад байсан гэжээ. Эрцгээж байтал гэнэт тулсан, доош хараад хэвтэж байсан, хамаг бие бие нь хөшчихсөн, доор нь илд байсан гэнэ. Тэнэмэл галаа сайн түлэхийг тушаагаад өөрөө алга болсон, одоо хүртэл ирээгүй ажээ.

Сэм Тэнэмэлийн талаар дахиад л эргэлзэж эхэлсэн бөгөөд цаадах нь харанхуйгаас чимээгүй гарч ирэхэд нь Фродог биеэрээ халхалж, илдээ сугалахад Тэнэмэл хараа ч үгүй юм шиг шархтаны дэргэд өвдөг сөхрөн суув.

- Үгүй ээ Сэм, би хар морьтнуудынх биш, тэдний гар хөл ч биш – гэж зөөлөн хэлээд – би тэднийг хаана нуугдсаныг л мэдэх гэсэн юм. Тэд дахиад довтлох ёстой атал яваад өглөө. Энэ надад ойлгомжгүй байна. Гэхдээ л ойр хавьд амьсгаа нь ч алга.

Фродо утга авцалдаагүй нэг юм ярихад тэр ихэд санаа зовж, толгой сэгсрэн хүндээр санаа алдав. Тэгээд Мерри, Пин хоёрт тасралтгүй ус буцалган шархыг нь угаагаад бай гэж тушаав.

- Галаа ингээд л дүрэлзүүлээд бай, түүнийг дулаан байлга! – гэж тэр тушаагаад галаас жаахан холдож Сэмийг дуудав:

- Одоо зарим юм ойлгомжтой болж байна, дайснууд тавуулаа дайрсан юм шиг байна. Бүгдээрээ цуглараагүй, тэгээд ч эсэргүүцнэ гэж тооцоолоогүй юм байна. Тэд эндээс явсан ч холдоогүй, маргааш шөнө эргээд ирнэ гэж би айж байна. Тэдэнд яарах юм алга, ажлаа бараг хийчихсэн гэж бодож байгаа. Бөгж холдохгүй. Чиний эзнийг санамсаргүй тохиолдлоор амьтай голтой үлдсэн, цаашдаа гараас гарахгүй гэж бодож байна. Ийм л юм шиг байна, гэвч юу болохыг харъя даа!

Сэм арчаагүй енгэнэн уйлав.

- Чи ингэж болохгүй шүү, надад найдаж үз! Танай Фродо миний санаснаас хавьгүй бөх амьтай юм байна. Гэндальф тийм үг цухуйлгаж байсан. Тэр гайхамшгаар амьд үлдлээ, одоо гол нь тэсэх л хэрэгтэй. Тэснэ ээ. Дайснууд үүнийг л ойлгохгүй. Би түүнийг эмчлэхийг хичээнэ. Сайн дулаацуулж, хамгаал. Ямар нэг юм болбол байдаг хоолойгоороо хашгирч, их

гал асаагаарай. Би удахгүй ирнэ- гэж аяархан яриад харанхуйд уусан алга болов.

Фродо зүүрмэглэж, өвдсөндөө сэрж байлаа. Мөр, гар, өрөөсөн тал нь аажмаар хөшиж байв. Анд нөхөд нь түүний шархыг эцэж цуцалгүй угааж, байдаг бололцоогоороо дулаацуулж байлаа. Шөнө удаан үргэлжилж, Тэнэмэлийг эргэж ирэхэд үүрийн гэгээ хонхорт туслаа.

- Хараач! – гэж тэр дуу алдаад одоо хүртэл хэн ч анзаараагүй байсан хар цувыг газраас авч харуулав. Хормой нь хүү татагдсан байлаа. – Манай Фродогийн кинжаал үүнийг хүүлжээ. Цувыг нь хүү татсан ч шархдуулж чадсангүй. Хаан удмын тэр үхдэлийг жирийн зэвсгээр хөнөөхгүй. Харин Элберет гэдэг нэр түүнд кинжаал дүрэхээс ч аюултай... харин манай Фродогийн шарх – тийм ээ, үүнээс аюултай шарх байхгүй!

Тэнэмэл дахин бөхийж, үүрийн гэгээнд хүйтэн өнгөөр гялалзсан урт нарийхан кинжаал газраас авлаа. Үзүүр нь хугарсан байх бөгөөд кинжаал харсаар байтал нарийн утаа савсуулан хайлж зөвхөн бариул нь үлдэв.

- Бидний байдалд ч муу байна даа – гэж тэр хэлээд – ийм аймшигтай шархыг эмчлэх хүн байхгүй гэж бод. Мэдээж, би чадах бүхнээ хийнэ, гэхдээ би их юм чадахгүй.

Тэр газарт суугаад, өвдөг дээрээ хар бариулыг тавьж, үл ойлгогдох хэлээр удаан аятай шившлэг дуулав. Дараа нь бариулыг хажуу тийш тавиад Фродогийн дээрээс бөхийж, чихэнд нь ямар нэг хачин үгс хэлэв. Бүсэндээ зүүж явдаг цүнхнээсээ урт навчнууд гаргаж ирлээ.

- Энэ бол эртний хэлээр ацэлас гэдэг эмийн ургамал. Эндхийн чулуурхаг хөрсөнд ургадаггүй, би шөнийн харанхуйгаар Их замаас өмнүүр байдаг шугуйгаас үнэрээр нь олж авсан юм.

Тэр навчийг хуруугаараа үрэхэд сайхан амтлаг, тун нарийн бөгөөд хүчтэй үнэр орчинд тархлаа.

- Аз таарна гэдэг энэ дээ, энэ навчны талаар манай умардад мөрдөгчдөөс өөр мэдэх хүн байхгүй. Тэд эртний буудлуудын дэргэдээс олж авдаг юм. Шидэт ургамал байгаа юм, хэрэв тус болбол түргэн эдгээнэ. .. Шарх нь даанч хүнд юм даа.

Тэр навчнуудаа буцалгаж, гашуун мөртөө анхилуун үнэрт хандаар Фродогийн шархадсан мөрийг угаав. Сэнгэнэсэн сайхан үнэр сэтгэл санаа сэргээн тайвшруулж байлаа. Фродогийн өвдөлт намдсан боловч мөс шиг хүйтэрч, хүндэрсэн гар нь биедээ наалдаад хөлдчихсэн юм шиг санагдана. Тэр дайсны тушаалаар бөгж зүүсэндээ өөрийгөө зүхэж байв. Одоо насаараа тахир татуу боллоо, цаашдаа яах болж байна? хөдлөх ч тэнхэл алга...

Энэ хооронд тэд цаашдаа яах тухайгаа хэлэлцэв. Эргүүлэг уулыг нэн даруй орхихоор шийдлээ.

- Бүх юм тодорхой. Энэ газар аль хэдийнээс дайсны хараанд байна. Хэрэв Гэндалф энд ирсэн бол дайснуудтай тулалдсаар холдож явсан. Бид дахиад энд нэг шөнийг өнгөрөөнө гэвэл дууслаа гэсэн үг, хаана ч очсон эндээс дээр – гэж Тэнэмэл хэлэв.

Үүр цаймагц хурдхан хооллоод хөдөллөө. Фродо явж чадахгүй тул ачааг нь дөрөв хувааж үүрээд, өөрийг нь пони дээр суулгав. Тартагтаа тулсан пони хэд хоногт гайхалтай хурдан сэргэж, тамир тэнхээ нэмэгдэн таргалах янз орсон ба шинэ эзэддээ, ялангуяа Сэмд сүрхий дасч байлаа. Цохиур түүнийг дэндүү хатуу ширүүн эдэлдэг байсан тул хамгийн бэрх зам ч өмнөх амьдралыг нь бодвол жаргал байлаа.

Тэд өмнө зүг явах ёстой боловч ойтой газар аль болохоор хурдан хүрэхийн тулд эхлээд их замыг гатлах хэрэгтэй байлаа. Тэгэхгүй бол гал түлэх мод олдохгүй, Тэнэмэл их гал өрдөж Фродог үргэлж дулаан байлгахыг хичээж байсан, тэгээд ч шөнийн цагаар гал тэдний хамгаалагч болж байлаа. Тэр бас алсуур тойрсон замыг шууд хөндлөн гарч цаг хожих бодолтой байв. Зам Эргүүлгийн зүүн бэлээс шууд хойд зүг рүү эргэж их урт үргэлжилж байв.

Тэд уулын баруун өмнөд хажуугаар далдуур, болгоомжтой явж, Их замд хүрээд хөндлөн гүйж гатлав. Зам дээр нүд хүрэх газарт хов хоосон байсан ч тэдний толгой дээгүүр булшны хоёр дуу хоолой хоорондоо дохио өгөлцөх нь сонсдов. Тэд байдгаараа бөхийж, хөлийн хурдаар гүйсээр өтгөн бут руу орлоо. Налуугаар явахад эргэн тойронд ганц жим ч харагдсангүй, нэг бол бут болон хатаж хатуурсан модон дундуур, нэг бол намгархаг шалчиг дундуур явж байв. Өвс ургамал нь сийрэг, модод нь өвсөн дээр үрчгэр хорчгор навчсаа унагана. Нүд булаах юмгүй энэ газраар тэд удаан, урамгүй урагшилж байв. Пони унасан Фродо толгой унжуулан алхаж яваа нөхдөө уйтгартайяа харж явна. Тэнэмэл хүртэл ядрангуй, дүнсгэр харагдана.

Фродогийн мөр мөс шиг хүйтнээр өвдөж байвч, ёолох зохимжгүй тул шүд зуун байдаг хүчээрээ тэсч байлаа. Нэгэн хэвийн, хүнд бэрх дөрвөн хоногийг авлаа. Харанхуй тэднийг айлгаж, шөнөдөө хоёр хоёроороо харуулд гарч, бүрэг саарал харанхуйг гэнэт хар толбонууд цоолон гарч ирэх вий хэмээн чичирч байлаа. Гэвч яаж ч хараад хар толбонууд гарч ирсэнгүй, зөвхөн хатсан өвсний хуурай шаржигнаан л сонсдоно. Эргүүлэг уулан дээр байсан шиг улаан дэргэд тулсан аюул мэдрэгдэхгүй байлаа. Морьтнууд тэднийг бүрмөсөн орхисон юм болов уу? Үгүй байлгүй дээ, хаа нэгтээ нуугдаад зам дээр нь отож байгаа байх.

Тав дахь өдрийн орой болж, мэдэгдэм төдий өгсүүр, нэлээд өргөн хөндийг гатлав. Тэнэмэл дахиад зүүн хойт зүг эргэж, тэд ихээ урт налууг туулан алсаас ойртох модтой ууланд дөхөж явлаа. Тэртээ доор Их зам бүрэлзэж, баруун талаас нэгэн гол бүүдгэр саарал өнгөөр туузран байв. Түүнээс цааш, будантсан чулуулаг хонхорт бас нэг гол байх шиг.

- Бид хүссэн ч хүсээгүй Их замаар нэг хэсэг явах байх гэж айж байна. Бидний өмнө Догшин гол буюу эльфээр Митейтиль гол байна. Энэ гол Уудам хөндийн умард талын хамгийн сайхан газар Эттенблатсаас эх авч өмнө зүгт Даргилаат голд цутгадаг юм. Энэ хоёр гол нийлээд Саарал урсгал нэртэй болдог. Их том гол учир Эттенблатаас доогуур гатлах аргагүй. Ганцхан гарц байгаа нь Эцсийн гүүр, Их зам тэр гүүрээр гардаг юм – гэж Тэнэмэл бодолхийлэн өгүүлэв.

- Өөр бас нэг гол байна аа даа? – гэж Мерри асуув.

- Тийм, тэр чинь Даргилаат, тэндээс Уудам хөндий ороход их ойрхон. Гэхдээ Эцсийн гүүрнээс тэр хүртэл их явна аа. Их зам ер нь их муруйдаг шүү дээ. Бид түрүүн гаталга өнгөртөл би энэ талаар бодсонгүй. Бид эхний удаад нэг гол гатлаад л болно. Гүүр чөлөөтэй

байвал бидний аз.

Аянчид өглөө эрт Их замд дахин дөхөж ирлээ. Тэнэмэл, Сэм хоёр тагнуулд яваад унаатай, унаагүй хэнийг ч олж харсангүй. Зам хоосон, морины мөр ч байхгүй, хоёр хоногийн өмнө энд бороо орсон байна, мөр бороонд угаагдсан, түүнээс хойш хэн ч яваагүй байж болно.

Алхаагаа түргэсгэж, байдаг хүчээрээ чармайж явгал нэг бээрийн цаана нэгэн уулын бэлд эцсийн гүүр харагдлаа. Уулын доороос хар морьтнууд гараад ирэх юм биш биз... юу ч харагдсангүй. Тэнэмэл тэднийг бутан дунд нуугд гэж тушаагаад өөрөө урагш явснаа төдөлгүй эргэж ирэв.

- Гүүрэн дээр дайсан алга байна, хаашаа алга болсныг нь л харин би мэдэхгүй байна. Гэхдээ би юу олсныг хар даа. Энийг би олгохгүй байна – гээд алгаа тэнийлгэж, цайвар ногоон чулуу үзүүлэв.

- Гүүрэн дээр, замын дунд хэвтэж байсан юм. Энэ бол эльфийн ногоон хаш чулуу. Тэмдэг болгож тавьсан юм уу, зүгээр унагаачихсан юм уу бүү мэд. Гэхдээ л найдвар төрүүлж байна. Тэгэхлээр гүүрэн дээр азаа үзнэ... тэгээд учир нь олдох байлгүй. Харин учир начир олдоогүй цагт замаар явахгүй – гэж тэр хэлэв.

Нэг ч хором сааталгүй гүүрээр эсэн мэнд гарав. Эргэн тойрон нам гүм, зөвхөн гурван том салаа гол л шуугина. Нэг бээр орчим яваад Тэнэмэл зүүн тийш эргэн нарийхан зөргөөр оров.

Хоббитууд царай муутай моддын дундуур сүлжиж явахдаа уйтгарт хонхор, айдаст Их зам ард хоцорсонд баяртай байсан боловч эндхийн газар зэлүүд, бөглүүд, цаанаа л нэг аюул үнэртсэн газар байлаа. Хоёр талаар уулс улам өндөрсөн шахна. Уулын орой, цохион дээр эртний хана хэрмийн үлдэгдэл, цамхагийн нуранги үзэгдэж, ямар нэг нууцлаг аюул тээж байгаа юм шиг. Фродо пони унаж яваа болохоор ийш тийш харж, бодол бодох боломжтой байв. Тэр “Тийшээ ба буцах замд” номын нэг хэсэгт Их замаас хойт зүгт, троллууд нутагладаг ойд баргар дүрт цамхагууд байсан, тэнд Бильбогийн анхны жинхэнэ адал явдал болсон тухай санаж байв. Одоо тэд яг тэр газарт ирээд байгаа юм биш үү?

- Энд хэн амьдардаг юм бэ? Энэ цамхгуудыг хэн босгосон юм бэ? Троллын өндөрлөг биш биз? – гэж тэр асуув.

- Тэр чинь мөн. Гэхдээ цамхгуудыг троллууд босгоогүй. Тэд барилга барьж чаддаггүй юм. Одоо энд хэн ч амьдардаггүй, урьд нь хүмүүс амьдардаг байсан, одоо байхгүй. Домогт өгүүлснээр бол тэднийг Ангмариин шидтэн хаан захирч байсан, тэгээд хүмүүс хортонд авгаж, их дайны үеэр хаантайгаа хамт үрэгдсэн. Уулс одоо тэднийг мартсан боловч хар хорын сүүдэр сарниагүй байгааг бид харж байна – гэж Тэнэмэл хариулав.

- Хүмүүс энд аль эртнээс амьдрахаа больсон юм бол чи тэр тухай яаж мэдэж байгаа юм бэ? Уулс хүртэл мартчихсан бол араатан, шувууд ярьж өгөхгүй биз дээ?

- Элендилийн залгамжлагчид эртний түүхийг мартаагүй, Уудам хөндийд ч гэсэн миний та нарт ярьж өгч чадахаас илүү ихийг санаж байгаа.

- Чи Уудам хөндийд байнга очдог уу?

- Очиж байсан, нэг хэсэг би тэнд амьдарч байсан, боломж олдох бүрт очиж байдаг, гэвч би тэнд амьдрах заяагүй юм шиг байна, мөнхийн тэнүүлч би Элрондын гайхамшигт цайзад идээшдэггүй бололтой.

Уулс тэднийг улам л шахсаар. Бруинен гол хүрэх зам тэртээ холд хоцорлоо. Аянчид хавцлын дундах нам гүм урт хөндий рүү орж ирлээ. Хадан цохион дээр мушгирсан, хөгшин боловч бат бөх үндэс нь ил харагдах модод сүглийж, налуу хажуугийн дээд хэсэгт нарсан ой өтгөрчээ.

Хоббитууд туйлдаж гүйцэв. Унанги модод, хад асган нуранги тээглэсэн зөрөг жимгүй газраар алхам алхмаар урагшилсаар. Хоёр дахь өдөр нь тэнгэр муухайрлаа. Баруунаас үлээх салхи Тэнгисийн зүгээс усан манан туун ирж, уулсын оргилоос бороо шивэрлээ. Үдэш болоход тэдний хамаг хувцас шалба норж, шөнө нь гал ч түлсэнгүй, уруу царайтай хонолоо. Өглөө нь уулс улам өндөрч, хөндий огт шаардлагагүй хойд зүг рүү хөтөллөө. Тэнэмэл хүртэл санаа нь зовж эхлэв. Эргүүлэг уулнаас бууснаас хойш арав хоног явж, хоолны нөөц дуусчээ. Бороо шивэрсээр л.

Хадан хясаа салхинд идэгдэж хонхор гаргасан чулуун агуйд хонов. Фродо өвчиндөө шаналсаар. Хүйтэн, чийгнээс болоод шарх нь улам өвчин орж, огт унтуулсангүй. Тэр эргэж хөрвөөж, шөнийн чимээ, салхины исгэрээг айж ширвээтэн сонсч байв. Хадны хонхорт салхи шүнгэнэн, уул хад хуухирч, том том чулуу өнхөрнө. Гэнэт хар хий үзэгдлүүд дэргэд нь ирсэн мэт санагдаж, одоо бүх юм өнгөрлөө гэж бодтол тэднийг хамгаалж тамхиа сорон нойргүй сууж байгаа Тэнэмэлийн нуруу харагдав. Фродо нуруугаараа хад налж, Хоббитан дахь өөрийнхөө цэцэрлэгийн анхилуун үнэрт зүлгэн дээгүүр зугаалж явна гэж зүүдлэн унтав.

Өглөө сэрэхэд бороо зогссон байлаа. Дээрээс дарах мэт тугалган өнгөт үүлс таран мөлхөж, цайвар хөх тэнгэр үзэгдэв. Салхины чиглэл дахин өөрчлөгдлөө. Амт муутай, хүйтэн хоол идсэний дараа Тэнэмэл агуйгаас хамраа ч битгий цухуйлгаарай гэж захичихаад, дээшээ гарч орчныг хараад ирье гээд яваад өгөв.

Тэр эргэж ирэхдээ муу мэдээ авчирлаа:

- Бид хойд зүг рүү хол явчихсан байна. Одоо шууд өмнө зүг рүү эргэхгүй бол умардын бөглүүд нутаг Эттенблат орчихно. Тэнд тролли нар эзэгнэдэг, би газар мэдэхгүй. Уудам хөндий рүү хойд талаас нь орж болох авч зам урт, би зам сайн мэдэхгүй, хоол хүнс ч хүрэлцэхгүй. Хүссэн ч, хүсээгүй ч Бруинений гарам руу явах хэрэгтэй байна – гэж тэр ярилаа.

Өдрийн хагаст тэд асга дундуур явлаа. Зүүн өмнө буюу хамгийн хэрэгтэй зүг рүү хөтөлсөн нэг хавцлаар орж, үдэш болоход хугархай хөрөө мэт хөндөлдсөн хадан нуруу замыг нь хаав. Нэг бол буцаж хаашаа явж байгаагаа ч мэдэхгүй явах, нэг бол яадаг ч байсан урагшаа явах хэрэгтэй боллоо.

Шууд дайраад гарах гэж оролдсон боловч тийм амархан байсангүй. Фродо нөхдөөсөө хоцрохгүйг хичээн яарч, хөл нь чичрэн өвдөг нь нугарч байв. Пони эгц өндөр өөд арайхийн авирч байв. Тэд жимээ байн байн алдаж байсан бөгөөд заримдаа жим байсан эсэхийг мэдэхээ

больж, ачаа улам хүндэрч байлаа. Харанхуй болохын өмнөхөн орой дээр гарахад тэд хөдлөх ч тэнхэлгүй болсон байв. Хөрөөний ир мэт иржгэр хадан дэл дундуур нарийхан гарц байсан бөгөөд буулт их эгц байв. Фродо нам унаж, чичрэн, уруулаа зууж хэвтэв. Зүүн гар нь амьгүй мэт унжиж, мөр, гар нь хүйт даан янгинаж байв. Модод болон хад чулуу бүдэгхэн сүүдэр мэт үзэгдэнэ.

- Цааш явж болохгүй – гэж Мерри Тэнэмэлд хэлээд – Фродо хөл дээрээ зогсч чадахгүй байна, өөрөө харж байна шүү дээ. Би түүний төлөө их айж байна. Бид одоо яах юм бэ? Уудам хөндийд хүрчихвэл түүнийг эмчилж чадах болов уу, чи юу гэж бодож байна?

- Очиж байж л мэдье, би одоо өөр юу ч хийж чадахгүй. Тэр шархадсан болохоор би ингэж их яараад байгаа юм шүү дээ. Харин өнөөдрийн хувьд бол цаашаа явж болохгүй, чиний зөв.

- Эзэн яачих нь энэ вэ? – гэж Сэм Тэнэмэл рүү наманчлан гуйх байдалтай харж аяархан асуугаад – шарх нь жижигхэн, эдгэрч эхэлсэн, одоо мөрөн дээр нь жижигхэн цагаан сорви л байна шүү дээ.

- Фродог Дайсны илд цоо хатгасан. Тэр бол хортой, шидтэй, үхлийн зэвсэг. Би энэ хар шидийг анагааж чадахгүй. Өөр чамд юу гэж хэлэх вэ дээ. Тэсч үз Сэм минь.

Өндөр хадан байц дээр шөнөдөө хүйтэн, аварга том нарсны тахирласан үндсэн дор түүдэг гал асаасан ч даарч байлаа. Нэгэн цагт эндээс шавар авдаг байсан бололтой. Хоббитууд жихүүцэн бие биедээ наалдаж суув. Хүйтэн салхи хүүгэж, доор байгаа модод санаа алдан ёолох нь сонсогдоно. Фродо хагас нойронд дарагдаж, дээгүүр нь хар далавчнууд дэвэн, далавчнууд дээр үхдэл сүгнүүд суугаад өөрийг нь хаана нуугдсаныг хайж байх мэт.

Цэлмэг, тунгалаг өглөө болж, агаар сэнгэнэн бороонд угагдсан цайвар тэнгэрт бүдэг гэгээ тусав. Аянчид бага зэрэг сэргэв. Хөл, гар бээрсэндээ хөшчихөж, жаахан нар ээгээсэй хэмээн хүсч байлаа. Үүр манхайтал цайсны дараа Тэнэмэл Мерриг дагуулан ойр орчныг ажиглахаар өмнөд оргил руу явлаа. Тэр хоёр царай нь гэгээтэй болчихсон эргэж ирэхэд нар хурцаар ээж байлаа. Тэд бараг зөв чиглэлд явж байна, одоо эгц хажуу руу бууж, уулыг зүүн гар талдаа орхих хэрэгтэй байлаа. Тэнэмэл Бруинений алсын саарал гялбааг дахин харлаа, гарамд хүрэх зам одоохондоо харагдахгүй байгаа боловч голын наад талын эргээс холгүй байгаа нь мэдэгдэж байв.

- Бид дахиад их зам дээр гарах хэрэгтэй байна, уулаар явж чадахгүй, юу ч боллоо гэсэн түүгээр явахаас өөр замгүй, амар хялбар зам бидэнд угаасаа байхгүй.

Өглөөний хоолоо яаран идээд замаа үргэлжлүүллээ. Өмнөд налуугаар аажуухан буухад өчигдрийнх шиг эгц биш байсан тул Фродог дахин пони дээр нь суулгалаа. Цохиур Бургаасны боол байсан тэр адгуус замаа гайхалтай сайхан сонгож, Фродогийн төлөө санаа тавьж байгаа мэт нэг ч сэгсрэхгүй явж байлаа. Аянчид бага багаар хөгжилдөж эхлэв. Фродо хүртэл өглөөний наранд өвчин зовлон нь хөнгөрсөн мэт байсан боловч нүд нь байн байн бүрэлзэх тул хоёр гараараа нүдээ үе үехэн арчиж явлаа.

Пин бусдаасаа түрүүлэн явж байснаа гэнэт “Хүүе ээ, энд жим байна” гэж хашгирав.

Хүрээд очтол нээрэн жим байна. Жим бэлээс дээш өгсөн бараа алдарчээ. Зарим хэсэгтээ өвс ногоонд хучигдаж, дээрээс нурсан чулуу, унанги модонд дарагдсан байхыг үзвэл урьд өмнө нэгэн цагт их л хөлтэй байсан бололтой, харин одоо үүгээр явахаа больжээ. Анх түүнийг гаргасан этгээд их л чадалтай байсны шинж. Бүдүүн бүдүүн моддыг цавчиж, асар том хясаануудыг хага цохин зайлуулсан байв.

Доош буухад хялбар байсан тул тэд жимээр буулаа, гэхдээ тэд маш болгоомжтой явж байв. Ялангуяа сүүдэрлэг ой руу орохдоо бүр ч сэрэмжтэй явж, жим нь улам өргөн, улам тод болж байлаа. Жим өтгөн ургасан гацуурын төгөл дундуур шурган гараад налуугаар доошилж, дараа нь аварга том цохионы цаагуур оржээ. Тэд жимээр явж цохиог тойртол жим нь битүү мод ургасан хясаан доогуур оржээ. Хадан хясаанд хаалга гаргасан байх бөгөөд тэр нь хагас нээлттэй, ганцхан нугасан дээр торж байв.

Хаалганы өмнө очоод зогслоо. Хаалганы цаана агуй юм уу ямар нэг оромж байгаа бололтой. Тэнэмэл, Сэм, Мерри гурав хамаг хүчээ нийлүүлэн байж гацсан хаалгыг нээж, Мерри, Тэнэмэл хоёр дотогш оров. Тэнд үжирсэн яс, хоосон домбо, хагархай ваар савнууд байв.

- Троллиудын ичээ байна, агуйгаас хурдан гарцгаа, тэгээд л байдаг хурдаараа зугтаая. Хэн энэ жимийг алга болгосон нь одоо тодорхой боллоо, тэднээс аль болохоор холдье – гэж Пин дуудав.

- Хаашаа яарах юм бэ – гэж Тэнэмэл агуйгаас гарч ирэх зуураа хэлээд – ичээ нь ч ичээ байна, гэхдээ аль эрт эзэнгүй болжээ. Айх юм алга. Үүгээр доош чимээгүйхэн бууя, буусан хойноо зугтаах хэрэгтэй болбол зугтаая- гэлээ.

Хаалганы өмнөх дэвслэгдсэн талбайгаас жим ойрхон байх налуугаар эгцээрээ урууджээ. Тэнэмэлийн өмнө айж байгаага мэдэгдэхгүйн тулд Пин урагш гүйж Мерриг гүйцэв. Тэнэмэл, Сэм хоёр Фродогийн унасан понийн хоёр талаар алхаж явав. Жим их өргөссөн тул тэд зэрэгцээд явсан ч болохоор байлаа. Гэвч цааш хол явсангүй. Пин хар хурдаараа буцан гүйж, араас нь Мерри гүйж ирэв. Хоёулаа үхтлээ айсан царайтай байв.

- Троллиуд, троллиуд! – гэж Пин мэдээлээд – Тэр доор, ойн цоорхойд байна, бид модны араас харсан. Аймаар том юмнууд байна – гэв.

- Очиж үзэцгээе – гэж Тэнэмэл хэлээд урт бүдүүн мөчир авав. Фродо дуугарсангүй, Сэм гайхан нүдээ бүлтийлгэв.

Нар өндөрт хөөрч, бараг навчгүй болсон мөчрүүдийн завсраар нэвт гийн ойн цоорхойг тод гэрэлтүүлж байлаа. Тэд ойн цоорхойг амьсгаа даран ажиглав. Өнөөх тролл гэдэг амьтад энэ байна. Асар том биетэй гурван тролл. Нэг нь бөхийн ямар нэг юм хийж, хоёр нь түүнийг харж зогсоно. Тэнэмэл тэдэн рүү юу ч болоогүй юм шиг хэнэггүй явж очив.

- Чи муу чулуужсан сүг! – гээд тэр тонгойсон троллын бөгс рүү бүдүүн мөчрөө хугартал цохив. Хоббитууд зэрэг дуу алдаж, Фродо тас тас хөхрөв.

- Өө за за! – гэж тэр дуу алдан хэлээд – сайн эрс бол доо, хэлэх юм алга. Гэр бүлийнхээ

түүхийг ч мартчих юм даа! Энэ гурав бол арван гурван гном, нэг хоббитоор яаж амттай хоол хийх вэ хэмээн маргаж байхад нь Гэндалф тааралдаж, чулуу болгосон тэр гурван тролл байна шүү дээ – гэлээ.

- Бид тэр газарт хүрээд ирчихсэн гэж даанч бодсонгүй шүү – гэж Пин гайхав. Тэрхүү гэр бүлийн түүхийг Пин сайн мэддэг, Бильбо, Фродо хоёр хичнээн ч удаа ярьсан билээ дээ. Үнэндээ тэр ярианд өчүүхэн төдий ч итгэдэггүй байж билээ. Одоо ч гэсэн тэр чулуун троллууд амь орно гэсэн шиг сэрэмжтэйгээ харж байлаа.

- Танай гэр бүлийн түүх ч яамай, та нар ядаж троллуудын тухай ямар нэг юм санасан нь дээр байлгүй – гэж Тэнэмэл мушилзан инээвхийлээд – үд боллоо, нар ээж байна, гэтэл та нар троллууд ойн цоорхойд нарлаж байна гээд байдаг! Юм мэдэхгүй байж болно, харин нэг троллын чихэнд шувууны хуучин үүр байгааг хармаар юм даа. Амьд тролл ийм гоёлтой байвал зүгээр юм биш үү!

Бүгдээрээ элгээ хөштөл хөхрөлдөв. Фродо Бильбогийн анхны азтай ажлыг баяртайяа санаад бие нь илааршчих шиг болов. Нар үнэхээр сайхан ээж, нүдний өмнөх будан арилж байв. Тэд ойн цоорхойд үдийн хоолоо идэв. Аварга том троллуудын хөлийн сүүдэрт хооллох сайхан байлаа.

- Нар ээж байгаа дээр хэн нэг нь дуу эхлэх юм биш биз? Бид дуу сонсолгүй удсан байна шүү – гэж Мерри хэлэв.

- Эргүүлэг уулнаас хойш сонсоогүй – гэж Фродо хэлэхэд бүгд түүн рүү харав.

- Надаас болсон юм биш ээ, миний бие их сайжирч байна, гэхдээ яаж дуулах вэ дээ, харин Сэм нэг юм бодох юм биш биз?

- За Сэм, хаашаа ч гарах аргагүй боллоо, эхлээрэй, бусад нь ажиллахгүй байвал толгойгоо ажиллуул! – гэж Мерри шавдуулав.

- Цаг нь болохоор юугаа ажиллуулахыг хараарай. За байз юу байж болох вэ, жишээ нь шүлэг гэхэд шүлэг биш, нэг тиймэрхүү дэмий юм байна. Нэгэнт надад даалгаж байгаа бол би аргалъя даа.

Сэм босч багшийн асуултад хариулж байгаа шавь шиг гараа ардаа аваад хуучны дуулийг унших, аялахын хооронд дуулав:

Ян халил дээр хөгшин тролл

Яс хэмлэж суухдаа ийн бодов:

“Ээ чааваас, идэхээс дээ!”...

Энэ ясыг тэр олон жил хэмлэсэн

Энэ бол яс хэмлэгчийн заяа!

Уул нь мах идэх ёстой агал

Уулан дээр суугаад яс хэмлэнэ.

Гэтэл тэнгэрээс унасан юм шиг

Гэнэт Үст Тавхай гүйгээд ирэв:

-Хэн энд миний хадам эхийн

Хэмх ясыг нохой шиг мэрнэ вэ?

Хар хулгайч, хар луйварчин минь!

Хэн чамд энэ хүндтэй газар

Хадмын минь ясыг хэмлэ гэсэн юм бэ?

-Хээр хэвтээ хөсрий ясыг

Хэнээс асууж авах юм бэ?

Харин одоо чи надад

Хариу хэлээд өг дөө:

Хадан дээр хаясан яс

Хадамд чинь нас нэмэх үү?

Хар тэнэг минь ээ!

Үзэн яддаг байсан хадмаа

Үхсэн хойно нь өмөөрч байна уу чи?

-Үхсэн хадам минь ясаараа

Үгүйрсэн чамайг хооллох гэж үү?

Үл үзэгдэх хадмын минь сүнс

Үйлт чамаас хариугаа авах биш үү?

-Битгий намайг доромжлоорой

Би чамайг залгичихна шүү!

Хоосон цэцэрхэж байж

Ходоодонд минь орчихов доо!

Олдохгүй бол яс мэрдэг

Олдвол амьдаар нь залгидаг би!

Аманд гүйгээд ордог

Амьд хоол ертөнцөд үгүй:

Үсэрч очоод Үст Тавхай

Үйлт троллын бөгс рүү өшиглөв.

Хорин жил нэг ч босолгүй

Хадан дээр суусан троллын бөгс

Хадтай наалдаад чулуужсан байжээ.

Төмөр гутал өмсөөгүй л юм бол

Тэнэг амьтан л хад өшиглөнө.

Тийм л юм болсон юм даа.

- Энэ чинь харин бидэнд сургамжтай юм байна шүү! – гэж Мерри инээгээд – Тэнэмэл чи тэрний бөгс рүү мунаа буулгасан нь сайн боллоо, гараараа цохисон бол юу болох байсныг мэдэж байна уу?

- Чи ч мундаг юм аа Сэм, би урьд нь ийм юм сонсч байгаагүй – гэж Пин магтав.

Сэм хариуд нь ямар нэг ойлгомжгүй юм бувтналаа.

- Сэм урьдаас бэлтгэчихсэн байсан уу, сая л санаанд нь орсон уу бүү мэд, ер нь цаашлах тусам л намайг гайхашруулаад байгаа. Урьд нь хуйвалдагч байсан, одоо хошин шогч боллоо, цаашдаа шидтэн ч юм уу, дайчин баатар болж гайхуулж магадгүй л боллоо – гэж Фродо хэлэв.

- Болохгүй ээ, аль аль нь миний хийж чадах ажил биш – гэж Сэм хэлэв.

Оройн нар ойт хажууг гийгүүлж, тэд нэгэн цагт Бильбо, Гэндальф хоёр гномуудтай явж байсан зөргөөр уруудлаа. Хэдэн бээр яваад Их замд тулж, аварга том далангийн дээр гарлаа. Их зам аль эрт нарийхан голдрилоор тонгочиж байгаа Догшин голоос холдож, ой руу нэг шургаж, бутан дундуур нэг зүссээр уулын бэлээр тахирлан алсын гарам руу тэмүүлж байв. Тэнэмэл далангийн дэргэдэх авсан доторх бүдүүлэг засалтай, нар салхинд гандаж элэгдсэн,

гномуудын рун бичиг болон ямар нэг нууц бичээс бүхий чулуу руу заалаа.

- Мөн хачин аа, энэ чинь троллуудын эрдэнэ хадгалагчийн тэмдэгт чулуу байна шүү дээ. Бильбод тэр эрдэнэсээс хэр их үлдсэн бэ, Фродо? – гэж Мерри асуув.

Фродо чулуу руу хараад “Бильбо энэ аюулгүй эрдэнэсээс өөр юу ч авчраагүй байсан бол, тэднээс ийм амархан салаагүй бол юу болох байсан бол?” гэж бодлоо.

- Юу ч үлдээгүй ээ, Бильбо сохор зоос ч үлдээлгүй тараачихсан, буруу замаар олсон баялаг юм болохгүй гэсэн.

Орой болж, нүд хүрэх газарт сүүдэр уртасч байлаа. Их зам урьдын адил хов хоосон. Тэдэнд өөр зам байгаагүй учир далангаас бууж, зүүн тийш эргэн байдгаараа хурдаллаа. Хажуу талаас шингэх нарыг хаасан урт гүвээ хөндөлсөж, өмнөөс нь хүйтэн салхи үлээлээ.

Тэд хонох газар хайж ийш тийш харж явтал гэнэт ар талаас зүрхэнд хүйт хуруулсан туурайн чимээ тод дуулдав. Бүгд зэрэг эргэж харсан боловч зам огцом эргэсэн тул юу ч харах боломжгүй байв. Тэд налуу өөд хөлийн хурдаар гүйж, бүрэнхий бүдэгрэн сааралтах Их замаас гучин фут орчим зайтай өтгөн бутанд нуугдав. Туурайн төвөргөөн улам ойртож, тов тодхон тачигнан, хазаарын амгайн чимэг хангир жингэр сонсдов.

- Хар морьтнуудтай нэг л төсгүй юм байна даа – гэж Фродо чих тавин сонсоод хэлэв.

Хоббитууд ч үнэхээр адилгүй юм байна гэж бодож байсан ч юу ч байж магадгүй хэмээн болгоомжилсон хэвээр байв. Олон өдөр мөрдөгдөн айж явсан болохоор ардаас сонсогдсон чимээ бүр тэдэнд аюул занал мэт сонсогдож байв. Гэтэл Тэнэмэл урагш тэмүүлэн алгаа чихэндээ нааж, нүүрэнд баяр баясгалан тодорч байлаа.

Бүрэнхий болж, бутан дээгүүр салхи гүйн сэрчигнүүлэв. Амгай зуузайн жингэнээн улам тодорч, туурайн төвөргөөн ойртсоор гэнэт замын эргэлтээр цагаан морь бүрэнхийд гэрэлт шувуу мэт дүүлэн гарч ирлээ. Хазаарын эрдэнийн чулуун чимэг тэнгэрийн одод мэт гялалзана. Морьтны цув салхинд дэрвэж, юүдэнгээ буулгасан тул алтлаг үс нь намиран байна. Морьтны биеэс хурц гэрэл цацарч байх шиг Фродод санагдав.

Тэнэмэл бутан дотроос үсрэн гарч баяртайгаар хашгиран зам руу гүйв. Түүнийг босохоос өмнө морьтон тэдний зүг харж, мориныхоо жолоог татсан байлаа. Тэнэмэлийг хараад тэр урдаас нь яаран ухасхийв.

- Аи на вэдуи Дунадан! Маэ гвэринниэн! – гэж тэр хашгирлаа.

Танихгүй морьтны энэ үг, цангинасан дуу хоолой тэднийг тэр дороо тайвшруулав. Дундад газарт зөвхөн эльфүүд л ингэж жиргэх мэт ярьдаг билээ. Гэвч түүний мэндийн үгэнд түгшүүр сонсдож, тэр Тэнэмэлтэй их л яаруу, түгшүүртэй ярьж байлаа.

Дараа нь Тэнэмэл тэднийг гараараа даллахад хоббитууд яаран доош буув.

- Энэ бол Асалдар, Элрондын цайзаас иржээ, - гэж Тэнэмэл хэлэв.

- Сайн уу, удаан хүлээсэн зочин минь, намайг та нарын урдаас явуулсан юм. Бид чиний төлөө их санаа зовж байлаа – гэж эльф дайчин Фродод хандаж хэлэв.

- Тэгэхлээр Гэндальф Уудам хөндийд байгаа байх нь ээ? – гэж Фродо хашгирав.

- Үгүй ээ, намайг наашаа гарахад тэнд байхгүй байсан, ес хоногийн өмнө явсан. Элрондод муу мэдээ очсон. Баруун газраар есөн бөгжтөн тэнэж явна, та нар Гэндальфыг хүлээлгүй газарчингүйгээр аюултай ачаа тээгээд алсын замд гарсан тухай манайхан танай нутгаар дайрч өнгөрөхдөө олж мэдэнгүүтээ бидэнд дуулгасан юм. Манай Уудам хөндийд ч гэсэн тэр естэй халз тулалдах хүчтэн цөөхөн боловч Элронд хойт, баруун, өмнө зүг рүү тагнуулчдаа илгээсэн. Та нар мөрдөлтөөс зугтаж, ширэнгэ ой руу ороод төөрч магадгүй шүү дээ. Би Их замыг тагнах үүрэг хүлээсэн, долоо хоногийн өмнө Митейтилийн гүүр хүрч, та нарт өөрийн тэмдэг цагаан хаш чулуу үлдээсэн. Гүүрний цаана Сауроны гурван туршуул нуугдаж байсан, тэд надаас зугтаад баруун зүг арилаад өгнө лээ. Би тэднийг мөрдөж яваад өөр хоёр туршуултай нь таарсан, тэр хоёр өмнө зүг рүү зугтсан. Тэгээд би та нарын мөрийг хайж, хоёр хоногийн өмнө олоод дахин гүүр рүү эргэсэн, өнөөдөр та нарыг уулнаас бууж явахад чинь харсан юм. За дараа ярих цаг олдоно. Одоо та нар аз сорьж үдэш, шөнөөр ил замаар явах болно. Бидний араас таван морьтон мөшгөж байгаа, мөрийг чинь олмогц салхинаас хурдан давхих болно. Бусад нь хаа явааг мэдэхгүй, бодвол гарам дээр отож байгаа биз. Энэ талаар одоо бодохгүй байсан нь дээр – гэж тэр ярилаа.

Энэ зуур үдшийн сүүдэр өтгөрч, Фродо тэсэхийн аргагүй их ядарч байгаагаа мэдрэв. Эхлээд нүдний өмнүүр сиймгэр хөшиг татах мэт болж байснаа дараа нь найзуудынх нь царай ч харагдахаа больжээ. Шарх нь өвдсөн хэвээр. Тэр нэг найгаад Сэмийн мөрийг дэрлэв.

- Эзэн маань шархадсан, бие нь их муу байна, тэр жаахан амрахгүй бол явж чадахгүй – гэж Сэм хэлэв.

Асалдар унаж байгаа Фродог түшин аваад гар дээрээ эвтэйхэн өргөж, нүүр рүү нь ихэд анхааралтай харав. Тэнэмэл Эргүүлэг уулан дээр болсон дайралтын талаар, үхлийн аюулт илдний тухай товчхон яриад, дайсны илдний бариулыг эльф дайчинд өгөв. Эльф түүнийг цээрлэнгүй аваад маш анхааралтай ажиглав.

- Энд хар шидийн бичээс байна, та нарт харагдахгүй. Хадгалчих Арагорн минь, Элрондод хэрэг болно. Харин нүднээс далд хийж, гараа хүргэхгүйг хичээ. Би ийм шархыг эмчилж чадахгүй. Чадах юмаа хийе, харин амрах тухай бодох ч хэрэггүй.

Тэр Фродогийн мөрийг барьж үзээд царай нь эвгүй болохыг үзвэл байдал сайнгүй байгаа бололтой. Фродо гэнэт зэвүүн хүйтэн өвдөлтийг бахим чанга сарвуугаар базан авч хаях шиг болохыг мэдэрч, гар нь бүлээцэн өвдөлт намдав.

Нүдний өмнөх хөшиг ч бөөн хар үүл сарних мэт алга болж, андуудынх нь царай манан дундаас тодрон харагдаж, бие нь хүч орж, найдвэр төрлөө.

- Миний морийг унаад яв, би дөрөөг нь саагаад өгье, явахад эвтэйхэн. Юунаас ч бүү ай, мориноос унана гэж байхгүй, би чамайг битгий унагаарай гэж мориндоо хэлчихнэ. Их

жигдхэн, хөнгөн давхина, хэрэв аюул тохиолдвол чамайг аваад л гарна. Дайсны хурдан хар морьд миний морийг яасан ч гүйцэхгүй.

- Би хаашаа ч давхихгүй, би өөрөө Уудам хөндийд эльфүүдийн дунд нуугдаад, найз нар маань энд үлдэх гэж үү? Үгүй шүү!

- Чиний найзууд чамгүйгээр балрахгүй – гэж Асалдар инээгээд – дайснууд чамайг хөөж яваа болохоос эднийг хөөж яваа биш, чи болон чиний авч яваа тэр юм чинь л бидэнд аюул тарина – гэв.

Татгалзах аргагүй учир Фродо эльфийн цагаан морийг уналаа. Тэд ачаагаа пони дээрээ ачсан тул өмнөхөөс хамаагүй хурдан, бүр маш хурдан урагшиллаа. Эльфийн алхааг гүйцэхийн тулд гүйх шахам явцгаав. Тэр тэднийг эхлээд үдшийн бүрий дундуур, дараа нь шөнийн харанхуй дундуур удирдан алхав. Сар ч, од ч байхгүй тас харанхуй. Үүрийн гэгээ тусахад Асалдар сая зогсов. Пин, Мерри, Сэм гурав хөл дээрээ арай ядан тогтож байв. Тэнэмэл хүртэл бөгтийж, Фродо морины дэлийг дэрлэн нам унтжээ.

Тэд Их замаас гарч, бутан дунд ороод тэр дороо унтацгаав. Гэвч Асалдар тэднийг удсан ч үгүй сэрээлээ. Өглөөн нар нүд гялбуулж, цэлмэг өдөр эхлэв.

- За ууцгаагаарай! – гэж Асалдар хэлээд мөнгөн чимэгтэй дашмагнаасаа ямар нэг шингэн аягалав.

Тэд ууж үзвэл яах аргагүй ус, тэгэхдээ хавар цагийн булгийн цэнгэг ус шиг, бүлээн ч биш, хүйтэн ч биш, ямар ч амтгүй мөртөө тэр дорхноо ядаргаа тайлагдан бие хөнгөрөөд явчихав. Дараа нь хатсан талх, хатаасан алим /өөр идэх юм үлдсэнгүй/ идэхэд Хоббитаны ямар ч элбэг дэлбэг амтат хоол идсэнээс илүү сайхан амттай, тэр дороо л цадав.

Таван цаг унтаад босч, эцэс төгсгөлгүй туузрах Их замын нугачаагаар яваад л байлаа, яваад л байлаа. Хоёрхон удаа түр сууж амрав. Орой болоход тэд хорь гаруй бээр явсан бөгөөд Бруинений гарам руу шууд хөтөлсөн замаар баруун тийш огцом эргэж, нам хөндий рүү оров. Хоббитууд соргогоор чимээ чагнан ийш тийш хараачилсаар явсан ч одоохондоо юу ч үзэгдсэнгүй. Асалдар тэднийг хоцорвол байн байн зогсч, түгшүүртэйгээр эргэн харж хүлээнэ. Тэр Тэнэмэлтэй нэг хоёр удаа эльф хэлээрээ товчхон ярив.

Газарчид хичнээн болгоомжилсон ч хоббитуудын алхаа удааширсаар байв. Тэд байсхийгээд л бүдэрч, хөлөө амраах ганц мөрөөдөлтэй явлаа. Фродогийн өвдөлт өчигдрийнхөөс хоёр дахин ихэсч, өдрийн наранд хүртэл дэлхий ертөнц бүүдгэр саарал өнгөтэй харагдан гандаж, хоосорсон мэт санагдаж байв.

Үүрийн гэгээнээр нойрмог, ядарсан, уруу царайтай хоббитууд дахиад л замаар гэлдэрлээ. Гарам хүрэх яагаа ч үгүй, хоббитууд унан тусан алхаж, газарчдаа арайхийн гүйцэж байлаа.

- Гол хүртэлх энэ хэсэгт л хамгийн аюултай, бидний улаан мөрөөр хөөж байгааг миний зүрх мэдэрч байна, бас гарам дээр биднийг отоож байгаа – гэж Асалдар хэлэв.

Зам өвсөрхөг хоёр хажуу бэлийн дундуур уруудахад хоббитууд хөлийн улааамраахын тулд зөөлөн өвсөн дээгүүр явж байв. Орой тийшээ хоёр талаас өтгөн нарсан ой шахаж, дараа нь зам хар хүрэн боржин хясаануудын дундах хавцал руу орлоо. Хоёр талын хадны цуурай тэдний хөлийн чимээг үй олон хөлийн чимээ, туурайн төвөргөөн болгож байв. Зам гэнэтхэн уудам газарт гарч, тэдний өмнө Гарам руу очих налуу цэлийж байв. Хавцлаас тэдний үлдээсэн үй олон хөлийн чимээ, туурайн төвөргөөн сонсодсон хэвээр, нарс моддын мөчир чичирхийлж байв. Асалдар эргэж харан чимээ чагнасхийснээ хоббитуудын урдаас хар хурдаараа гүйв:

- Давхиарай! Фродо! Дайснаас холд!-гэж тэр хашгирлаа.

Цагаан морь дүүлэн ухасхийж, хоббитууд налуу руу гүйлдэн, Асалдар, Тэнэмэл араас нь гүйв. Ар талаас нь туурайн төвөргөөн цуурайлж, хавцлаас нэг хар морьт нисэх мэт хурдлан гарч ирснээ эмээл дээрээ ганхан жолоогоо татлаа. Түүний хойноос нэг хар морьт, дахиад нэг, дахиад хоёр гарч ирлээ.

- Давхиарай! Урагшаа! – гэж Асалдар дахин хашгирав. Гэвч Фродо жолоогоо сул тавив. Түүний бие нэг л хачин сулраад явчихлаа. Морь нь тээнэгэлзсэн янзтай алхалж, Фродо эргэж харлаа. Морьтнууд хөшөө мэт хөдөлгөөнгүй харлан харагдаж, ард нь саарал тоос манарна. Гэнэт Фродогийн айдас, уур хоёр зэрэг дүрсхийв. Тэр жолоогоо тавьж, наранд улайран гялалзах илдээ сугаллаа.

- Давхиач! Давхиач дээ! – гэж Асалдар хашгираад мориндоо эльф хэлээр: - Нора Лим, нора лим, Асфалот!- гэж захирангүй бөгөөд чанга хэлэв.

Цагаан морь ухасхийж, замаар салхинаас хурдан давхилаа. Хар морьд ч дүүлэн ухасхийж, саяхан Хоббитаны өмнөд тойрогт сонссон хамаг бие хүйт оргиулсан улиан сонсогдлоо. Хариу улих дуун сонсдож, модны цаанаас дахиад дөрвөн хар морьт дүүлэн гарч ирлээ. Хоёр нь Фродогийн араас, хоёр нь амаж, гарам руу давхилаа. Тэднийг шуурга тууж байгаа мэт, тэдний хар нөмрөг улам улам тэлэн дэрвэж байв.

Фродо дахин эргэж харахад найз нар нь үзэгдсэнгүй. Хар морьд хичнээн галзуу мэт хурдлавч Асалдарын цагаан морийг яагаад ч гүйцэхгүй нь илэрхий байв.

Гэвч урагшаа хартал ямар ч найдваргүй болсон нь илэрхий байв. Тэр гарам хүрч чадахгүй нь, хоёр хар морьт амдан барьж авна. Одоо тэр хоёр тод харагдаж байна. Юүдэн ч үгүй, цув ч үгүй, саарал хуяг, цагаан өмсгөл, урт хөх банзал. Ясан гарт нь илд гялалзаж, нүд рүүгээ дарж өмссөн дуулган дороос нүд нь гялалзаж, галзуу улиан нь чих янгинуулна.

Фродо айдаст хүлэгдэв. Илдээ ч мартчихаж, хашгирья гэтэл хоолой нь таг, гараа ч хөдөлгөхөөс айж байв. Нүдээ аниад мориныхоо дэлд наалдлаа. Чихэнд нь салхи исгэрч, мөнгөн хонх нэг л сонин исгэрэх мэт жингэнэнэ. Цэвдэг хүйтэн биеийг нь дахин нэвтэлж, мэдээ алдарч байсан ч эльф морь сум мэт суга үсрэн эхний хар морины хамрыг шүргэх шахам өнгөрөөд гол руу нисэх мэт хурдаллаа.

Ус пүл палхийж, эргэн тойрон ус цацран, усанд шумбах мэт болсноо дээш өргөгдөхөд нүдээ

нээв. Морь чулуурхаг замаар өгсөн хурдалж, гарам ард үлдлээ.

Гэвч хар морьтнууд хөөсөөр. Нэлээд эгц налуугаар даваад Фродогийн морь зогсч, гол руу эргээд хангинатал янцгаав. Нөгөө эрэг дээр голд тулан есөн хар морьтон харлан эгнэж зогсчээ. Фродо үхдэлүүдийн аймшигт царайг харахаас эмээн чичирч байв. Тэдэнд гол гатлах юу ч биш, харин Фродо Уудам хөндий хүртэл урт замаар давхих болно, хар морьтууд гүйцэхээ л гүйцнэ, хаашаа ч зайлахгүй нь гэж бодлоо. Бүү хөдөл! гэсэн дуугүй тушаал мэдрэгдэж, дахиад уур нь буцалсан боловч эсэргүүцэх хүч байсангүй.

Эхний хар морьт морио давирахад морь нь уснаас айж цоройв. Фродо хэмжээлшгүй их хүчлэн байж нуруугаа тэнийлгэж, илдээ өргөлөө.

- Зайлцгаа!, Мордор руугаа тонил, би та нарт бууж өгөхгүй!- гэж тэр хашгирлаа.

Морьтнууд зогссон хэвээр боловч Фродогийн тасалданги дуу Бомбадилынх шиг сүр хүчин төгс байсангүй. Түүнд сөөнгө, үхмэл хөхрөлдөөн сонсдов:

- Нааш ир! Нааш ир! –гэж тэд дуу нийлүүлэн хашгираад – Чи манайх, чиний байх газар бол Мордор! – гэгцгээв.

- Зайлцгаа! – гэж Фродо шивнэх шахам хэлэв.

- Бөгж! Бөгж өгөөдөх, Бөгж! – гэж булшны дуун хадав. Толгойлогч нь морио давиран гол руу ороход хоёр нь араас нь орлоо.

- Элберетийн нэрийн өмнөөс, сайхан Лучиэний нэрээр тангараглая – гэж Фродо хэлээд илдээ өргөж – бөгжийг та нарт өгөхгүй. Би ч танайх биш!-гэж хашгирлаа.

Тэгтэл гармын тэг дунд хүрч явсан толгойлогч дөрөөн дээрээ босон гараа заналтайгаар өргөхөд Фродо таг дуугүй болов. Хэл нь хоолой руугаа татагдаж, чичирсэн гараас нь илд сугаран унав. Эхний хар морьт наад эрэгт хүрэхэд эльф морь тургиж, дээш цоройв.

Гэтэл чих дөжрөм их нижигнээн болж, голын ус буцлах мэт хуйлран, том том чулуу үсчүүлэн урсгав. Голын ус дээш хөөрөн, оволзох давалгаа нь асар олон морьтон довглох мэт, Цагаан морьд, цагаан нөмрөгт баатрууд, асарлан дэрвэлзэх дэл их давалгаанд тодрох шиг харагдав. Давалгаа гурван хар морьтыг нөмрөн авч, хоромхон зуурын дотор хөөс бургилуулсан усан авсандаа хаман авч одов. Үлдсэн зургаа нь арагш ухарлаа. Яахаа мэдэхгүй нөгөө эрэгт тээнэгэлзэн байгаа зургаан хар морьтны цаана гэрэл цацруулсан цагаан хуягтай их баатар, бүх ертөнцийн саарал мананг бамбарын улаан гэрлээр нэвт гийгүүлсэн олон баатруудын дүрс харагдах шиг, нойрон дунд алсаас тэд хашгиралдах шиг болов.

Хар морьд айж цочсондоо голын сүрт давалгаан руу харайн орж, оволзсон хөөс, оргилсон хад чулуун дунд алга болж байгаа хар морьтнуудын хашгирааныг их голын сүрт давалгааны хүрхрээн дарж байлаа. Мориноосоо унаж байхдаа Фродо нүргэлсэн давалгаанд дайснуудтайгаа хамт үрэгдэх юм байна даа гэж бодож амжив. Тэгээд ухаан алдлаа.

Бүлэг 13

Санамсаргүй зочид

Фродо ухаан орж, нүдээ нээгээд орон дээр хэвтэж байгаагаа ойлгов. Эхлээд удаан үргэлжилсэн муухай зүүдний дараа жаахан унтаад сэрэхэд бие сэтгэл таагүй байна гэж бодов. Тэгэхлээр гэртээ байгаа юм байна, харин юу зүүдэлсэн юм бол? Эсвэл удаан өвчилсөн юм болов уу? Гэвч түүний байгаа өрөөний тааз нэг л сонин, өндөр, налуу, уран нарийн угалзан хээтэй. Фродо босохыг огт хүссэнгүй, тохилог өрөөнд дулаан хөнжилд хэвтэн ханан дахь нарны тусгалыг харж, алсын хүрхрээний чимээг сонсон байлаа.

- Би хаана байна аа? Одоо хэдэн цаг болж байна? – гэж тэр тааз руу харан өөрөөсөө чанга асуув.

- Элрондын цайзад байна. Одоо манайд өглөөний арван цаг болж байна. Хэрэв чи мэдэхийг хүсч байгаа бол өнөөдөр аравдугаар сарын дөрвөн – гэж хэн нэгэн хариулав.

- Гэндальф уу? – гэж Фродо дуу алдан өндийв. Үнэхээр тийм байлаа. Нээлттэй цонхны дэргэдэх тохилог буйдан сандал дээр өвгөн шидтэн сууж байв.

- Тийм ээ, би энд байна, хамгийн гайхалтай нь чи ч гэсэн зам зууртаа баахан тэнэглэж будилсны эцэст бас л энд байна – гэж тэр хэлэв.

Фродо дуугарсангүй, дахин дээш харж хэвтэв. Маргалдана гэхэд дэндүү сайхан тав тухтай, гол нь маргалаа ч гэсэн Гэндальфыг давж гарахгүй гэдгээ тэр сайн мэдэж байв. Хэсэг унтаад сэрэхдээ дөнгөж саяхан болж өнгөрсөн аяллынхаа аймшигт мөчүүдийг: Мөнхийн ой руу “зам товчилж” явсан, “Дүүхэлзэгч пони морь” буудлаас зугтсан, Эргүүлэг уулын бэлд бөгжийг хуруундаа угласан ухаангүй тэнэг явдал - гээд бүгдийг аажмаар нэгмөсөн сэргээн санах. Фродо тэр үйл явдлуудаа бодож, Уудам хөндийд яаж ирснээ санах гээд юу ч санахгүй гайхаж байх зуур Гэндальф гаансаа дуугүй сорж, утаан цагаригнуудыг цонхоор цувуулан суув.

- Сэм хаана байна? Бусад нь ч гэсэн, тэдэнд юу ч тохиолдоогүй биз?

- Тайван бай, бүгдээрээ амьд мэнд, Сэм чамайг сахиж суусан, сая надад хөөгдөөд гарсан. Жаахан унтаж амраг, гучин минут унтаж байна.

- Гармын дэргэд юу болсон юм бэ? Бид Уудам хөндийд дөхөж ирэхэд ертөнц нэг л хачин хоосон юм шиг санагдаад байсан, тэрнээс хойш юу болсныг би огт санахгүй байна.

- Тэгэхгүй яах юм бэ! Чи өөрөө мөрнийхөө шархнаас болоод бараг задарч, оргүй алга болох дөхсөн юм чинь. Энэ шарх чамайг үгүй хийх дөхсөн. Та нар гарман дээр хоёр цаг хожимдож очсон бол чамайг хэн ч аварч чадахгүй байсан. Гэлээ ч гэсэн чи гайхалтай их тэсвэр хатуужилтай юм байна. Чамайг магтахаас өөр яах билээ, эрхэм хоббит минь. Булшинд чи ёстой баатар байсан. Эргүүлэг уулан дээр Дайсанд автсан чинь л харамсалтай байна.

- Чи олон зүйл мэдэж байгаа бололтой – гээд Фродо Гэндальф руу гайхан харж – булшны тэнд болсон явдлын тухай би хэнд ч яриагүй. Эхлээд эргэж санахаас айгаад байсан, дараа нь ярих цаг ч гараагүй. Гэтэл чи бүгдийг мэдэж байдаг – гэв.

- Чи зүүдэндээ яриад байсан, би чиний ой ухааныг төвөггүй судалсан. Гэхдээ одоо чи юунд ч санаа зовох шаардлагагүй. Та нар их сайн байсан, яахав заримдаа тийм ч мэргэн шийдвэр гаргаж байгаагүй л дээ. Дайсны эрж байгаа бөгжийг аваад ийм холын, аюултай аялал хийхэд та нар багагүй эр зориг гаргалаа.

- Бид Тэнэмэлгүйгээр энд ирж чадахгүй байсан, харин чи хаана байсан юм бэ? Чамгүйгээр би юу хийхээ мэдэхгүй байсан.

- Намайг барьж авсан юм. Бид бүгдээрээ баларч болох байлаа... дашрамд хэлэхэд би одоо юунд ч найдахгүй байна, магадгүй бүх юм сайн тийш эргэсэн ч байж болох юм.

- Хэн чамайг барьсан гэж?

- Бүү яар, мэдэж авах цаг бий. Өнөөдөр чи их ярьж болохгүй...их сонсч ч болохгүй. Элронд тэгж байна.

- Гэвч ярих, сонсох хоёр бодсоноос хөнгөн. Бодох илүү ядаргаатай. Би ухаан оронгуут үй олон ойлгомжгүй үйл явдлыг санаж байна. Хэн чамайг барьсан юм бэ? Ядаж үүнийг яриад өг л дөө!

- Бүх юм өөрийн цаг хугацаатай. Чиний биеийг сайжрахаар бид Зөвлөлийн хурал хийнэ. Тэгэхээр чи бүгдийг мэдэж авна. Одоо би чамд ганцхан юм хэлье. Намайг урвагчид занганд оруулсан.

- Чамайг уу даа? – гэж Фродо итгэлгүйхэн асуув.

- Тийм ээ, намайг, Саарал Гэндальфыг занганд оруулсан. Ертөнцөд агуу их хүчтэн олон бий. Сайн нь ч бий, муу нь ч бий. Би хүртэл заримаас нь ухардаг юм. Заримтай нь би тулгарч ч үзээгүй. Гэвч одоо аймшигт их тулаанаас зайлах газаргүй болсон. Хар морьтнууд Андиуныг гаталсан. Энэ бол дайн эхэлж байна гэсэн үг.

- Тэгэхлээр чи хар морьтнуудын талаар бүр намайг тэдэнтэй тулгарахаас өмнө мэдэж байсан байх нь ээ?

- Мэдэж байсан, бүр тэдний тухай нэг удаа чамд ярьж байсан, яагаад гэвэл хар морьтнууд бол Хар Эзний есөн бөгжтөн зарц. Гэвч би тэд дахиад гараад ирснийг мэдээгүй, мэдсэн бол би чамайг Хоббитанаас аваад явах байлаа. Би зургадугаар сард чамаас салахдаа тэдний тухай мэдсэн... гэхдээ энэ талаар чи дараа мэдэж авна. Намайг алс өмнөдөд барьсан, мөхлийн аюулаас биднийг Арагорн аварсан даа.

- Тийм ээ, түүнгүйгээр бид сүйрэх байсан. Түүнийг анх хараад бид айсан шүү. Сэм түүнд огт итгэхгүй байсан, лав л Асалдартай уулзах хүртэл итгээгүй.

- Энэ тухай ч би сонссон – гээд Гэндальф инээвхийлж. – Одоо Сэм түүнд итгэсэн шиг итгэж байна лээ гэлээ.

- Энэ чинь маш сайн хэрэг, Тэнэмэл надад маш их таалагдсан. Бүр үүнээс ч илүү, би түүнийг эр хүн эр хүнээ хайрладаг шиг жинхэнээсээ хайрлаж байна... тэхдээ тэр хачин хүн л дээ, заримдаа бидэнд аймшигтай санагддаг байсан. Тэр чамайг надад байн байн сануулдаг байсан шүү. Үлэмж биет хүмүүсийн дунд Тэнэмэл шиг хүн олон байдаг уу? Би тэднийг зүгээр л том биетэй, бүдүүлэг, ухаалаг биш, Лавр Наркисс шиг сайхан сэтгэлтэй мөртөө тэнэгдүү, Цохиур Бургаас шиг аюултай гэж боддог байсан юм. Манай Хоббитанд хүмүүс бараг үзэгддэггүй, бид тэднийг зөвхөн Уулын сууринд л харсан юм шүү дээ.

- Хэрэв чи Лаврыг тэнэг гэж бодож байгаа бол уулынхныг тун муу мэдэж байна – гээд Гэндальф жуумасхийгээд – тэрний хэл нь толгойноосоо түрүүлж ажилладаг боловч мөн чанартаа маш ухаалаг хүн шүү, эргэлзэх хэрэггүй. Тэр өөрийнхөө ашгийг гарамгай олж хардаг юм, уулынхны ярьдгаар гурван давхар тоосгон хананы цаанаас ч харна. Гэхдээ Дундад газарт Арахорны хүү Арагорн шиг хүн цөөхөн дөө. Нэртэн вангуудаас бараг үлдээгүй. Бөгжний төлөө их дайнд Арагорныхны сүүлчийн үр удам тасарч ч магадгүй.

- Чи Тэнэмэлийн өвөг дээдэс нь Нэртэн вангууд гэж хэлэх гэж байна уу? – хэмээн Фродо чихэндээ итгэлгүйхэн асуугаад – тэднийхний удам одоо ч тасраагүй байгаа юм уу? Гэтэл би түүнийг зүгээр л тэнүүлчин гэж бодож байсан шүү - гэлээ.

- Тэнүүлчин гэв үү? Тэгвэл мэдэж ав. Дундынхан бол Баруун Вангуудын агуу хүчит омгийн хойт нутгийн үр удам. Урьд цагт тэд надад огт тусалж байгаагүй, харин ирээдүйд бид бүхэнд тэдний тусламж маш их хэрэг болно. Бид Уудам хөндийд эсэн мэнд ирлээ, гэвч бөгж энд үүрд орших хувьгүй юм байна, хүүе би юу хэлчихэв ээ...

- Тийм юм шиг байна аа – гэж Фродо зөвшөөрөөд – гэвч би энд л хүрчихвэл цаашаа явах шаардлагагүй гэж бодож байсан л даа, бүтэн сар харийн газарт тэнэлээ, энэ надад хангалттай, одоо би сайхан амармаар байна – гэснээ нүдээ анин дуугүй болов. Тэгснээ дахин ярьж эхэллээ.

- Миний тооцоо зөв байна. Өнөөдөр дөнгөж есдүгээр сарын хорин нэгэн. Яагаад гэвэл бид Гарман дээр хоринд ирсэн.

- Хангалттай, чи одоо ядарч болохгүй, Элрондын зөв..., мөр чинь яаж байна?

- Мэдэхгүй ээ, яагаа ч үгүй л юм шиг байна, гар ч хөдөлж байх шиг, би ер нь бүр эдгэчихсэн юм биш үү? – гээд биеэ хөдөлгөж үзсэнээ баруун гараа зүүн мөрөндөө хүргээд - хүйтэн биш байна – гэлээ.

- Гайхалтай, чи их хурдан эдгэрч байна. Удахгүй Элронд чамайг босохыг зөвшөөрнө, тэр энэ хэд хоногт чиний шархыг эмчилсэн юм... – гэв.

- Хэд хоног гэнэ ээ? – гэж Фродо гайхан үгийг нь таслав.

- Чи энд гурван өдөр, дөрвөн шөнө хэвтэж байна. Эльфүүд чамайг хорины орой авчирсан, чи ухаан ч ороогүй байхдаа унтаад өгсөн. Тэгээд л чи өнөөдөр хорин нэгэн гэж бодоод байхгүй юу. Бид их сандарсан, чиний үнэнч зарц Сэм өдөр, шөнөгүй чиний дэргэд байсан, Элрондын бүх даалгаврыг биелүүлсэн. Элронд бол мэдлэгтэй бөгөөд туршлагатай анагаагч, гэхдээ Дайсны зэвсэг хайр найргүй, бас үхлийн аюултай. Илдний үзүүр чиний биед үлдсэн байх гэж би сэжиглэж байсан, үнэнийг хэлэхэд тэрнийг илрүүлж авч хаях боломжтой гэдэгт итгэхгүй байсан. Элронд өчигдөр л тэр хэлтэрхийг тэмтэрч олсон, тэр биед чинь гүн орж, зүрх рүү чинь их ойрхон хүрсэн байсан.

Фродо Тэнэмэлийн гарт алга болсон хөрөө шиг иртэй илдийг санаад овгосхийн цочив.

- Бүү ай, Элронд тэрнийг чиний биеэс авч хаяснаас хойш тэр үүрд алга болсон. Харин чи хоббитууд энэ ертөнцийн төлөө баатарлагаар тэмцэж чадна гэдгийг батлан харууллаа. Миний мэдэх үлэмж биетүүдийн эрэлхэг хүчирхэг олон дайчин моргулийн илднээс ийм шарх авбал долоо хоногийн дотор алга болно, гэтэл чи бүтэн арван долоо хоног тэслээ.

- Тэр хар морьтнууд яагаад ийм их аюултай байдаг юм бэ? Тэд надаар яах гэсэн юм бэ, тайлбарлаад өгөөч?

- Тэд чиний зүрхэнд моргулийн илд шаах гэсэн юм. Илдний хэлтэрхий биед үлдээд зүрх рүү явна. Хэрэв тэдний зорилго биелсэн бол чи тэдний адил үзэгдэх биегүй болно, гэхдээ тэднээс сул дорой, тэдний дуулгаварт зарц болох байсан. Чи Харанхуйн хаанчлалын хий үзэгдэл болж, Хар Эзэн чамайг бөгжийг нь эзэмших гэж оролдсоны төлөө мөнхөд тарчлаах байсан. Нэгэн цагт чиний эзэмшиж явсан тэр бөгжийг түүний хуруунд байхыг харахаас өөр аймшиг байхгүй.

- Би ийм аюул байгааг мэдэхгүй байсан нь сайн хэрэг – гэж Фродо дахин чичрэнгээ шивнээд – тэртэй тэргүй би үхтлээ айж байсан, хэрэв би тэр үед юугаараа дэнчин тавьж байгаага мэдсэн бол хөдлөх ч зүрх хүрэхгүй байжээ. Би яаж аврагдсанаа ойлгохгүй байна.

- Чи онцгой хувь заяатай юм шиг байна... би чиний эр зориг, тууштай сэтгэлийн тухай яриагүй байна. Чиний эр зоригийн ачаар хар морьт илдээ зүрхэнд чинь дүрж чадаагүй, зөвхөн мөрийг чинь шархдуулсан. Гэвч чи шархадсан хойноо ч жинхэнэ баатарлагаар эсэргүүцсэн учраас илдний хэлтэрхий зүрхэнд чинь хүрэлгүй арван долоо хоножээ. Гэхдээ л чи үхлийн ирмэг дээр байсан. Дайсан чамд бөгжөө зүү гэж тушаасан. Чи түүнийг зүүмэгц хоосон ертөнцийн нэг хэсэг болсон. Чи хар морьтнуудыг, тэд чамайг харж байсан. Чи өөрөө тэдний гарт яваад орсон юм шиг болсон доо.

- Би мэдэж байна аа, ямар их аймшигтай байсныг, ялангуяа шөнө .. би бүх насаараа санаж явах болно. Бид яагаад тэдний хар морьдыг үзэж байгаа юм бэ?

- Яагаад гэвэл тэр морьд амьд, мах цусаар бүтсэн. Морьтнуудын цув ч гэсэн хамгийн энгийн. Хувцас нь тэдний биегүй амийг бүрж байдаг юм.

- Тэгвэл амьд морьд биегүй эздээсээ яагаад айдаггүй юм бэ? өөр бусад ямар ч амьтанд биегүй сүнс ойртвол айна биз дээ? Ноход гаслана, галуунууд байдгаараа орилж гүйлдэнэ...

Асалдарын морь хүртэл яаж айж байсан гээч!

- Яагаад гэвэл тэр морьдыг Мордор оронд Хар Эзний зарц нарын унаа болгож хувиргасан. Хар Эзний зарц бүр хий үзэгдэл биш. Тэрэнд бас өөр төрлийн зарц олон бий. Орхууд, троллууд, бааснууд, чоно долоонууд, тэр ч байтугай олон хүн: хаад ноёд, дайчин жанжид тэрэнд захирагддаг. Тиймээс ч тэр улам их газар орныг эрхэндээ оруулж байгаа юм.

- Тэгвэл Уудам хөндий? Эльфүүд? Тэр эднийг захирч чаддаггүй биз дээ?

- Одоо бол үгүй. Гэвч тэр бүх ертөнцийг эзлэх юм бол эльфүүд ч тэсэхгүй. Бүгдээрээ биш ч гэсэн олон эльф Хар Эзнээс айж байгаа, тэд түүний сүр хүчинд дарагдах болно. .. Гэхдээ тэр тэднийг захирч, атгандаа оруулж, холбоо байгуулж чадахгүй нь нэгэнт илэрхий болсон. Энэ Уудам хөндийд тэрний гол өрсөлдөгчид байгаа, бараг л түүнтэй эн тэнцүү хүчирхэг эльфүүд. Би эртний Эльдар-далайн чанадынхны тухай ярьж байна. Тэд бөгжний хий үзэгдлүүдээс айдаггүй, яагаад гэвэл тэд Ариун газарт төрсөн, тиймээс тэдэнд Хоосон ертөнц хүртээлгүй. Тэд бол өнгөрсөн үед үзэгдэх биетэй, үзэгдэх биегүй олон дайсныг дарсан баатрууд.

- Гарамын тэнд би эргэж харахад хар морьтнуудын хажууд гэрэл цацарсан цагаан баатар гэрч ирэх шиг болсон. Тэр Асалдар мөн байсан уу? – гэж Фродо итгэл муутайхан асуув.

- Тийм ээ – гэж шидтэн хариулаад хэсэг зуур дуугүй байснаа – Асалдар чамд бодитой болоод бодигүй, үзэгдэх болоод үл үзэгдэх амьд хоёр ертөнцийг хослуулан харуулсан, яагаад гэвэл тэр бол эхэн төрмөлийн агуу их ван. Нэг үгээр хэлэхэд бусад газарт ч гэсэн Дайсныг түр тогтоох хүчин олдоно, танай намуухан Хоббитанаас ч олдоно. Хэрэв үйл явдал өөрөөр өрнөхгүй бол чөлөөт газар орнууд Хар Эзний далайгаар хүрээлэгдсэн арлууд болж хувирна. Тэдгээрийг Мордорын захирагч захирна... Одоохондоо – гэж тэр хэлээд үгээ таслан босоход сахал нь сүртэйеэ сөрвийж - Бид одоо эр зориг гарган тайван байх хэрэгтэй. Хэрэв өнөөдөр би чамайг сульдаж унатал чинь ярихгүй бол хэд хоногийн дараа чи эрүүл болно. Энд, Уудам хөндийд нэг хэсэгтээ бидэнд ямар ч аюул байхгүй, тиймээс чи тайван бай.

- Эр зориг надад алга, хадгалж хамгаалах ч юм алга, айх ч юм алга. Миний найз нарын тухай яриад өг л дөө. Тэгвэл би бүрмөсөн тайвширна. Яагаад ч юм нойр хүрээд байна. Хэрэв чи тэдэнд юу тохиолдсон талаар ярихгүй бол тэртэй тэргүй би унтаж чадахгүй.

Гэндалф буйдан сандлаа Фродогийн оронд дөхүүлээд түүнийг сонжсон байртай харав. Хоббитын хацар хөөрхөн улаа бутарч, нүд нь тайван бөгөөд тод тунгалаг байлаа. Тэр ч бүү хэл хөгжилтэйеэ инээмсэглэж, эв эрүүл харагдаж байв. Гэлээ ч гэсэн бараг нүдэнд баригдамгүй зарим нэг өөрчлөлт байгааг шидтэн олж харлаа. Учир нь хөнжил дээр хөдөлгөөнгүй тавиастай байгаа хоббитын зүүн гар цусгүй, тэр ч байтугай мах булчингүй мэт харагдаж байгааг анзаарав.

- Харамсалтай нь үүнээс зайлах арга байхгүй, энэ хүн замынхаа хагасыг ч туулаагүй байна... замаа туулж дуусахаар юу болохыг Элронд хүртэл урьдаас хэлж чадахгүй биз. Юу ч гэсэн сайн юм болно гэж найдацгаая... – Магадгүй дотоод жинхэнэ гэрлийг тунгалгаас ялгах чадвартай хүнд бол доторх шингэн нь харагддаг болор сав шиг тунгалаг харагдаж ч мэднэ. .. – гэж Гэндалф хамар дороо бувтнаад:

– Харахад чи эв эрүүл байна, найз нарынхаа тухай сонсоход чамд муу юм болохгүй гэж би бодлоо. Би Элрондоос зөвшөөрөл авахгүй, товчхон шиг яриад чиний нойронд саад болохгүйн тулд гарлаа. Миний олж мэдсэнээр гармын тэнд юу болсон тухай ярья. Чамайг гол дээр давхиж хүрэнгүүт хар морьтнууд хойноос чинь хөөсөн. Эргүүлэг уулан дээр чи тэдний ертөнцөд орсон болохоор тэд мориныхоо нүдээр биш өөрсдийнхөө хараагаар чамайг харж байсан. Түүнээс гадна тэднийг бөгж залж байсан. Тэдний морьд найзуудыг чинь няц гишгэлэх байсан тул найзууд чинь тэдэнд зам тавьж өгөхөөс өөр арга байгаагүй. Тэднийг саатуулах аргагүй учир морьтнууд есүүлээ чамайг нэхсэн. Арагорн, Асалдар хоёр тэдэнтэй тулалдаад дийлэхээргүй байсан. Бөгжтөнгүүт чамайг элдэж одсоны дараа найзууд чинь гол дээр гүйж очсон. Гармаас холгүйхэн, яг замын дэргэд модон дотор нууцхан хонхор байдаг, найзууд чинь тэр хонхорт гүйж ороод багахан түүдэг гал асаасан. Учир нь морьтнууд гол руу орвол Элронд голыг үерлүүлнэ гэж Асалдар мэдэж байсан юм. Морьтнууд чамайг гүйцэхгүй боловч эрэг дээр үлдсэнтэй нь тулалдах хэрэгтэй байсан юм. Гол оволзон үерлэнгүүт Арагорн, Асалдар хоёр найзуудыг чинь дагуулан гал бариад зам дээр гарчээ. Морьтнууд гал, ус хоёрын хооронд хавчигдаж, Асалдарыг танингуут галзуу зориг нь мохож, морьд нь олон гал, оволзсон уснаас айсандаа баримжаа алдаж, эздэдээ захирагдахаа больсон. Гурван морьтон чамайг барих гэж гол руу ороод гэнэтийн их үеэрт үйгдсэн. Үлдсэн зургааг морьд нь аваад гол руу орж урссан.

- Тэгэхлээр тэд үхсэн байх нь ээ? – гэж Фродо баярлан дуу алдав.

- Харамсалтай нь үгүй, үерт тэдний морьд л үхсэн.. . гэхдээ морьгүй морьтон гэж юу байх билээ? Тэд яаран зайлахаас өөр аргагүй болсон. Тэднийг устгах боломжгүй ч гэсэн удаан хугацаагаар алга болно гэж бодож байна. .. Голын үер намдмагц найзууд чинь голоор гаталж, чамайг олсон байна лээ. Чи түрүүлгээ харан хэвтэж байсан, хамаг бие чинь мөс шиг хүйтэн, царай чинь цав цагаан болчихсон, хугарсан илд чинь доор нь байсан. Асалдарын морь дэргэд чинь зогсч байсан. Арагорн чамайг үхүүлэхгүй юмсан гэж их хичээжээ. Муу юмны тухай бодох зав байсангүй. Чамайг аваад Уудам хөндий рүү явах замд эльфүүд тааралдсан байна.

- Морьтнууд яагаад голын уурыг хүргэсэн юм бол?

- Тэд бол эльфүүдийн заяаны дайснууд, Элронд бол энэ газар орны эзэн хаан. Дайснууд энэ хязгаарт ирэхэд гол мөрөн Элрондын тушаалаар үерлэж, дайснуудыг егүүтгэдэг юм. Бөгжтөнүүдийн толгойлогч гол руу ормогц гол аймшигтай үерлэсэн. Би ч гэсэн зүгээр байгаагүй, голын уур хилэнг улам бадрааж өгсөн, хэрэв чи харж амжсан бол үерийн хамгийн эхний давалгаа нь хүчирхэг цагаан морьтнууд болон хөөсөрч, морьтой баатруудын араас асар том хад чулуу хуйларч байсан даа. Гол тэгж их үерлэхийг хараад бид арай хэтрүүлчихлээ, одоо зогсоож чадахгүй байх гэж айсан боловч гол тэгсгээд намдаж, найзуудыг чинь урсгачихаагүй.

- Тийм тийм, санаж байна, би аймшигт их хүржигнээн нижигнээн сонсоод бид цөмөөрөө, би, найзууд, морьтнууд цөм дууслаа гэж бодсон. Гэтэл одоо бидэнд ямар ч аюулгүй болжээ!

Гэндалф Фродо руу ширүүн харахад тэр дуугүй болоод нүдээ аньсан байв.

- Чиний зөв өө, бидэнд ямар ч аюул заналхийлээгүй, одоохондоо шүү дээ... Чамайг хоёр хөл

дээрээ босмогц бид Гарам дээрх ялалтыг нижгэр тэмдэглэнэ. Энэ баярыг чамд, Арагорнд, чиний аян замын нөхдөд зориулна.

- Бидэнд зориулах гэж үү? Асалдар, Элронд хоёр бидэнд ямар ч шалтгаангүйгээр тусалж, аварч байгаагийн учрыг би олохгүй байна.

- Шалтгаан ч бий л дээ, үнэнийг хэлэхэд нэг биш шалтгаан байгаа – гээд Гэндальф хөнгөхөн инээмсэглэж – нэгдүгээрт би тэр хоёроос гуйсан, хоёрдугаарт бөгжийг чамд итгэж хадгалуулсан, гуравдугаарт чи Бильбогийн хамаатан, бас өв залгамжлагч, Бильбо бөгжийг ертөнцөд гаргаж ирсэн шүү дээ.

- Бильбо минь! Чи одоо хаана байна даа? – Фродо нойрмог дуугаар бувгнав.

- Яаж хөглөж явснаа түүнд ярих юмсан, ёстой инээдийг нь хүргэх байх даа... – гээд Фродо унтлаа.

Ингээд Фродо дорно зүгийн Сүүлчийн гэгээн ертөнцөд амьд мэнд ирлээ. Бильбогийн ярьсанчлан энэ газар идэж ууж, унтаж, аян зам, адал явдлаа ярьж, дуу дуулж, шүлэг уншиж, задгай галын дэргэд суун бодож сэтгэж, эсвэл зүгээр л юу ч хийлгүй байх сайхан ажээ. Тэнд очсон хэн ч гэсэн хоромхон зуурт ядаргаа нь тайлагдаж, санаа сэтгэлийн дарамт, айдас, өвчин зовлонгоос салдаг гэж Бильбо Хоббитанд байхдаа ярьж байсан билээ.

Фродо орой нь сэрэхэд бие нь цоо эрүүл болсноо мэдэрч, маш их идэж, лонх дарс залгилаад дараа нь шүлэг уншиж, хөгжилтэй дуу аялан, аян замынхаа тухай ярихыг туйлаас хүсч байлаа. Тэр хөнжлөө хуу татаж хаяад, орноосоо үсрэн буухад зүүн гар нь урьдын шигээ хэвийн ажиллаж байгааг мэдэж ихэд баярлав. Орны дэргэдэх сандал дээр хувцас байна. Түүнийг унтаж байх хойгуур оёсон бололтой шинэ хувцас биед нь маш сайхан таарч байлаа. Хувцсаа өмсөөд толинд хартал маш их турснаа мэдээд гайхаж хоцров. Нэгэн цагт Бильбо гэртээ авчирч байсан цэл залуу Фродо харагдаж байвч нүдний харц нь элдвийг үзэж ухаажсан хоббитын харц байлаа.

- Тийм ээ, Хоббитанаас гарахад толинд харснаас хойш чи их өөрчлөгдсөн байна, харин одоо эндхийн баяр наадмыг хар даа! – гэж тэр өөртөө хэлээд гараа алдлан сайн гэгч суниаж авав.

Хаалга тогшиж, Сэм орж ирэв. Тэр баяртайяа инээмсэглэн хүрч ирээд, зүүн гарыг нь зөөлхөн илээд буруу харлаа.

- Сайн уу, Сэм

- Хүүе, халуу оргиж байна шүү дээ, таны зүүн гар! – хэмээн Сэм хашгирах шахам хэлээд – Яг л мөс шиг хүйтэн байсан юм, хүйтэн нь яахав гэхэд өнгөгүй тунгалаг болчихсон байсан юм. Одоо бүх аюул ард хоцорсон. Гэндальф намайг явуулсан юм, таныг баярт бэлэн байна уу мэдээд ир гэсэн... Тэр надаар тохуу хийж байна гэж бодсон шүү.

- Бүрэн бэлэн байна, найзуудыгаа харах сан гэж тэсч ядан хүлээж байна

- Би таныг дагуулаад явъя. Энэ шилтгээн дэндүү том, гайхамшигтай гоё. Бүгдийг нь үзэж мэдэж авсан мөртөө гэнэт ер бусын сонин юм олныг үзнэ. Эльфүүдийг ямар гээч! Тэд эндхийн эзэд юм байна. Хаашаа л харна эльф! Зарим нь их ширүүн дүртэй, харахаас аймаар, тэгээд бас их сайхан! Гэтэл зарим нь ердөө л нялх хүүхэд шиг. Эргэн тойрон дуу хөгжим... Би учрыг нь сайн олоогүй л байна, надад цаг зав ч байгаагүй, бас зориг зүрх ч дутаад байна...

- Чи яагаад завгүй байсныг би мэдэж байна аа, гэсэн ч өнөөдөр цөмөөрөө сайхан наргина аа! Явъя, чи надад эндхийн гайхамшгийг үзүүлээд өг.

Тэр хоёр олон хаалгаар орж гарч, хэд хэдэн налуу шатаар уруудаад голын эрэг дээрх асар уудам цэцэрлэгт орж ирэв. Шилтгээний зүүн талд байх том сүүдрэвч дотор нөхөд нь сууж байлаа. Голын цаад хөндийд үдшийн бүрий өтгөрч, зүүн талын уулсын оргилууд дээр жаргах нарны туяа наадаж байлаа. Үдшийн бүрий тунгалаг бөгөөд дулаан, алсад нэгэн их хүрхрээ хүржигнэн шуугиж, агаар тэнгэр цэцэгсийн анхилуун сүрчиг, өвс ногоо, өнгөт навчсын үнэрт согтож, Элрондын энэ цэцэрлэгт саяхан болоод өнгөрсөн зун саатан амарч авай.

- Хур-р-р-рай! – гэж Пин дэвхцэн – манай буянт буурал гараад ирлээ! Бөгжний эзэн Фродо мандтугай хэмээн хашгирав.

- Ухаантай бай! – гэж сүүдрэвчийн алсын буланд сууж байсан Гэндалф түүнийг дуугүй болгоод – Энэ хөндийд дайснууд ирж чадахгүй боловч тэднийг дуудаж хэрэггүй. Бөгжний эзэн гэж Фродог нэрлэдэггүй, Мордорын Хар шилтгээний эзнийг нэрлэдэг юм. Бид найдвартай газарт нуугдсан боловч түүний хар сүүдэр ертөнцийг дахин нөмөрч, энэ шилтгээний эргэн тойронд харанхуй өтгөрч байна – гэлээ.

- За эхлэх нь энэ дээ – гэж Пин бувтнаад Фродод хандаж:

- Тэр дандаа биднийг ингэж тайвшруулж байгаа юм. Бид бэлэн, сэрэмжтэй байх хэрэгтэй гэдгийг би мэдэж байна. Гэвч энэ шилтгээнд муу муухайн тухай бодох ч боломжгүй. Би энд цаг үргэлж л дуулаад баймаар байна. Даанч тохирох дууг нь мэдэхгүй юм даа – гэлээ.

- Би ч гэсэн дуулмаар байна – гэж Фродо жаргалтайгаар инээн өгүүлээд гэхдээ эхлээд идэж уумаар л байна – гэв.

- Энд тэрэн шиг амархан юм байхгүй. Тэгээд ч чиний хамар чамд үнэнч хэвээрээ байна, одоо яг үдийн хоолны цаг- гэж Пин инээн өгүүлэв.

- Үдийн хоол биш ээ, найр – гэж Мерри түүний үгийг таслаад- чамайг илааршиж байна гэж Гэндалф зарлангуут найрын бэлтгэл эхэлсэн, бид агуу том найранд орно гэж би бодож байгаа шүү... - гэж Мерри хэлж гүйцээгүй байтал зочдыг найрын ширээнд урьсан хонх жингэнэв.

Зочид урт урт ширээнүүд эгнүүлэн тавьсан зоогийн танхимд орлоо. Ширээнүүдийн дээд талд арай зайтай гол ширээнд энэ орны эзэн хаан Элронд, хоёр талд нь Гэндалф, Асалдар хоёр суужээ.

Фродо тэдэн рүү хараад хараад ханахгүй байлаа. Тоо томшгүй олон домгийн баатар Элрондыг тэр анх удаагаа харж байна, урьд дэндүү танил байсан Гэндальф, Асалдар хоёр жинхэнэ төрөлдөө орж, хэнд ч ялагдашгүй, бүхнээс алдартай баатрууд харагдана.

Гэндальф эльфүүдээс нуруугаар намхан боловч цав цагаан сахал, мөнгөлөг урт үс, өргөн цээж, бурханлаг төрх нь түүнд жинхэнэ эзэн хааны дүрийг бүрдүүлж өгчээ. Өтгөн хөмсөг дорх соргог хоёр нүд нь дутуу унтарсан цучил мэт, хэрэгтэй цагт хэзээ хэзээгүй дүрэлзэн асах их гал мэт.

Өндөр гоолиг, хүчирхэг Асалдарын үс алтан очис цацруулан цэл залуу мэт харагдавч нүд нь цэцэн мэргэн ухаан, эрэлхэг баатарлаг зоригийг нь илтгэн байв.

Элрондын хэдэн настайг таах аргагүй боловч тоолшгүй олон баяр, гунигт үйл явдлуудын ул мөр нүүрэнд нь үлдсэнийг эс тооцвол цэл залуу харагдаж байлаа. Үнсэн өнгөт өтгөн үсэн дээр нь мөнгөн титэм бүдэгхэн гялалзаж, хөхөвтөр саарал нүд нь үл баригдах очис цацруулан байв. Тэр эртний мэргэн хаан, асар их туршлагатай агуу дайчин баатар гэдэг нь харваас илт.

Элрондын өөдөөс харсан шүхэрт буйдан сандал дээр үзэсгэлэн гоо нь дэндсэн гэмээр нэгэн бүсгүй сууж байх бөгөөд түүний энхрий зөөлөн, уяхан ялдам нүүр царайд гэрийн эзний эрэлхэг баатарлаг дүр төрх тодорч байв. Фродо тэр хатагтайг анхааралтай хараад энэ бол Элрондын зочин биш, садан төрөл нь юм байна гэж мэдлээ. Тэр хатагтай цэл залуу байсан уу гэвэл тийм ч, бас үгүй ч харагдана. Үл мэдэг мөнгөн сор үсийг нь буурал харагдуулсангүй, царай нь дөнгөж сая өглөөн шүүдрийн усаар угаасан мэт өнгөлөг, орь залуу насны оч бадруулж, харц нь үүр шөнийн заагаар цэлмэг тэнгэрт гялалзах од мэт хурц туяа цацруулна. Тэр хоёр нүдэнд дэлхий ертөнц дээр туулж өнгөрүүлсэн амьдралын их туршлагын үр дүн цэцэн мэргэн ухаан нуугдаж байлаа. Жижигхэн мөнгөн титэмд нь дүгрэг сувднууд туяарч, элдэв чамин чимэглэлгүй саарал даашинзных нь захан дээгүүр нарийн мөнгөн утсаар оёсон жижигхэн навчин эрих хөвөөлжээ.

Энэ бол Элрондын охин Арвен байсан бөгөөд түүнийг үхэлт төрөлхтнүүдээс тоотой хэд нь л харсан, ардын аман домгоор бол түүнд Лучиэний хойт дүр дэлхийд эргэж ирсэн гэдэг ба эльфүүд түүнийг Андомиэль гэж нэрлэдэг, тэдний хувьд Арвен үүрийн цолмон ажээ. Андомиэль саяхан Лориэнаас ирсэн бөгөөд уулсын чанад дахь тэр оронд түүний эхийн талын төрөл садангууд амьдардаг ажгуу. Элрондын хүү Элладан, Элроир хоёр умард нутгийн хаа нэгтээ аялж яваа, учир нь тэр хоёр ээжийг нь тарчлаасан умардын орхуудаас ээжийнхээ өшөөг авахаар андгайлсан аж.

Андомиэлийн гоо үзэсгэлэн Фродог бишрүүлж, мах цусанд төрсөн амьтан ийм нүдгялбам гоо сайхан гэдэгт итгэж ядан байсан бөгөөд өөрт нь Элрондын ширээний дэргэд суудал зассаныг мэдээд ийм өндөр хүндэтгэл хүлээсэндээ бараг айж байлаа. Хэд хэдэн дэртэй онцгой буйдан суудал нь бусад зочдоос дээгүүр байсан боловч өөрөө хамт зоог барьж байгаа аваргуудын дэргэд өчүүхэн мэт санагдаж байв. Гэвч энэ мэдрэмж тэр дороо алга боллоо. Найрын уур амьсгал чөлөөтэй, илэн далангүй, тэгээд ч элбэг дэлбэг, гайхалтай амттай зоог түүнд нэн ихээр таалагдсан тул тэр ерөнхийдөө тавагнуудаас нүдээ салгасангүй.

Гэвч гэдсээ цадаад ирэхээр тэр толгойгоо өндийлгөж найз нараа нүдээрээ хайв. Тэд- үнэнч

анд Сэм, Пин, Мерри гурав нь хажуугийн ширээнд сууж байлаа. Сэм эзэндээ үйлчлэх гэж зүтгээд, наад хоёр нь чи бол энд зарц биш, хүндэт зочин гэж ятгаж байв. Харин Тэнэмэл харагдсангүй.

Фродогийн баруун талд ер бусын чухал царайлсан, тансаг хувцасласан нэгэн гном сууж байв. Хоёр салаалсан буурал сахал нь нүд гялбуулсан цагаан цамцан дээгүүр нь намирч, сийлбэрт мөнгөн бүсийг нь халхална. Том гэгчийн алтан бугуйвч дээр нь өнгө өнгийн туяа цацруулсан очир эрдэнэ гялалзана. Фродо өөрийг нь ажиглаж байгааг мэдээд тэр эргэж харан:

- Сайн байна уу, цэцэглээд бай даа хүндэт хоббит минь! – гээд суудлаасаа босч мэхийн ёслоод: - Гном Глоин. Танд үйлчлэхэд бэлэн байна – гэснээ дахин мэхийн ёслов.

Фродо гайхсан боловч сандарсангүй. Тэр бас босохдоо дэрнүүдээ унагаасан ч тоосонгүй, хариу хэлэв:

- Фродо Торбинс. Танд болоод танай хүндэт ах дүү нарт үйлчлэхэд бэлэн гээд мэхийн ёсолж – Та алдарт Царсан Бамбай Торины хамтрагч Глоин мөн үү? – гэж асуув.

- Яг тийм – гэж гном хариулаад шалан дээр унасан дэрнүүдийг авч өгч, Фродог суудал дээрээ гарахад нь туслаад – Би чамд иймэрхүү асуулт тавихгүй, чи бол бүхний хүндлэлийг хүлээсэн Бильбо Торбинсын хамаатан, өв залгамжлагч нь гэж надад хэлсэн, Уудам хөндийд ирсэнд чинь баяр хүргэе! -гэлээ.

- Баярлалаа - гэж Фродо чин сэтгэлээсээ талархал илэрхийлэв.

- Чамд болон чиний дагуулуудад аяны замд хачирхалтай, бас аймшигтай сорилтууд тулгарсан гэж би сонссон... Нэгэн цагт Бильбо гав ганцаараа алсын аялалд гарсан шиг ганц хоббит биш, дөрвийн дөрвөн хоббит юуны тулд ийм бэрх аялалд гарсныг мэдэхсэн гэж хорхойсч байна. Элронд, Гэндалф хоёр энэ талаар яриад байх хэрэггүй гэдгийг надад ойлгуулсан л даа.

- Тэдний мэргэн ухаанд би эргэлзэхгүй – гэж Фродо болгоомжтой бөгөөд эелдгээр хариулаад – би ч гэсэн бүхэнд хүндлэгдсэн эрхэм гном Уулын хаант улс дахь эдлэнгээ орхиод энэ алс холын аюултай аялалд гарсныг мэдэхсэн гэж тэсч ядаж байгаагаа хэлэх ёстой гэлээ. Элрондын зочилж байхдаа ч гэсэн бөгжний талаар ярих хэрэггүй гэж тэр шийдсэн, ярих ч хүсэлгүй байлаа.

- Элронд, Гэндалф хоёрын мэргэн ухаанд эргэлзэх хэрэггүй – гэж Глоин нарийн ухаан сийлсэн шинжтэй инээвхийлээд – тэр хоёр Зөвлөл хуралдуулах гэж байгаа, тэгэхэд олон зүйл мэдэж авна гэж бодож байна – гээд тэр дахин инээвхийлж – харин одоо... хоёулаа өөр юм яривал яасан юм бэ? гэв.

Тэр хоёр учиртайхан харц солилцоод төрөлх газар орныхоо тухай бараг найр тартал үргэлжилсэн яриа болов. Ерөнхийдөө Глоин ярьж Фродо сонсч байв. Учир нь Хоббитан орныг чухал том үйл явдлууд тойрон өнгөрч байгаа, харин энэ гномоос сонсох зүйл их байгаа гэж Фродо бодсон, тэгээд ч бөгжний тухай дурсах ч хэрэггүй гэж шийдсэн байлаа. Тэр

Манант уулс, Балар шугуйн хоорондын газар орны захирагч нь Беорны хүү Гримбеорн болсон, түүний уудам нутгийн хилийг орхууд ч, чонодолоохууд ч зөрчиж зүрхэлдэггүй тухай ярилаа.

- Хөндийн орноос Уудам хөндийн орон хүртэл Гримбеорны дайчдын ачаар л айх аюулгүй зорчиж болно. Тэд Уулын даваа, Хэцийн гармыг хамгаалж байгаа... Тэдний татвар өндөр, гномуудад сайнаар ханддаггүй хэвээрээ – гээд Глоин толгой сэгсэрч - гэхдээ тэд итгэлийг яасан ч эвдэхгүй, өнөө үед энэ маш чухал. Харин Хөндий дэх нуурын вант улсын хүмүүс бидэнд их найрсаг ханддаг. Одоо тэр орныг Бейний ууган хүү, Нумчин Бардаагийн ач хүү Бранд ноён захирч байгаа. Тэр их уран ухаантай ноён болохоор газар нутаг нь өмнө зүгт их тэлж, Эсгаротоос Урт нуур хүрчихээд байгаа.

- Танай ард түмэн ямар байна даа?

- Манайд маш олон үйл явдал болж өнгөрсөн. Сайн ч бий, муу ч бий. Гэхдээ ямар ч гэсэн сайн нь муугаасаа олон. Одоо хүртэл бид их азтай хэвээрээ байна. Дундад газар дээгүүр аймшигт аюулын хар үүл хуралдаж байгаа нь бидэнд мэдрэгдэж л байна. Хэрэв чи хүсвэл би дэлгэрэнгүй ярьж өгнө. Харин миний ярианд ядарвал шууд хэлээрэй. Гномууд өөрийнхөө ажил хэргийг ярихаараа дөргүй үхэр шиг болдог гэсэн үг бий.

Тэгээд Глоин Уулын хаант улсынхаа тухай дэлгэрэнгүй ярилаа. Фродо түүний үгийг нэг ч тасалсангүй, ядарч байгаагаа ч мэдэгдсэнгүй, өөрөө бараг ярьсангүй. Гэвч хорь гаруй минутын дараа огт сонсч байгаагүй олон газар ус, хаад, баатруудын нэрэнд будилж, ярьж байгаа зүйлийг нь бараг ойлгохоо болив. Гэхдээ Дайнагийн тухай мэдээ түүнийг баярлуулав. Тэр одоо ч гэсэн Уулын хаант улсыг захирсан хэвээр юм байна, тэр хоёр зуун тавин нэгэн настай, хэн бүхний хайр хүндэтгэлийг хүлээсэн хэвээрээ, гномуудын баялаг улам арвижсаар байгаа юм байна. Түүнтэй хамт аян дайнд явж байсан арван баатар дайчнаас долоо нь Уулын хаант улсад амьдарч байгаа юм байна. Двалин, Глоин, Дари, Кори, Бифур, Бофур, бүдүүн Бомбур. Бүдүүн Бомбур одоо хоолны ширээнд ч хүрч чадахааргүй таргалсан, хоол идэхэд нь зургаан залуу өргөж ширээнд суулгадаг болсон юм байх.

- Нөгөө гурав нь яасан бэ? - Опи, Ори, Валян гурав?

- Явцгаачихсан – гээд Глоины царай барайж – тэр талаар яримааргүй байна. Өөр хөгжилтэй юм ярья. Манайд ховорхон тохиолдох урчууд байдаг. Гэхдээ одоогийн зэвсгийн дархчууд эртний дархчуудыг гүйцэхгүй. Эртний олон нарийн нууц эрдэм мартагдсан. Гном урчуудын урласан зэр зэвсэг, хуяг дуулга Дундад газар даяар алдартай. Луунууд Уулын орныг эзлэхээс өмнөх үеийн хуяг дуулга өнөөгийнхөөс бат бэх, илд, кинжаал нь ч илүү хурц байсан юм. Гэхдээ өнөө үеийнхэн газрын баялаг ашиглах, барилга барих талаар өвөг дээдсээсээ хол түрүүлсэн. Чи манай суваг шуудуу, өнгөт хавтангаар тавьсан зам, Гоонь уулын доогуур тавьсан чулуун модтой хонгил гудамжууд, харуул манааны цамхгуудыг харах юм бол биширнэ. Тэр цагт Уулын хаант улсад цагийг зүгээр алдаагүй юм байна гэдгийг өөрийн нүдээр харах болно.

- Завшаан тохиовол би танай оронд заавал очно оо, Бильбо тэр их өөрчлөлтийг харвал ямар их гайхах бол!

- Чи Бильбод их хайртай байсан биз? – гэж Глоин хэлээд Фродо руу харж зальжин инээмсэглэв.

- Хэлээд яахав, түүнтэй би ганцхан удаа зуурхан ч гэсэн уулзахын төлөө энэ ертөнцийн бүх гайхамшигийг өгөхөд бэлэн байна!

Энэ хооронд дайллага өндөрлөх тийшээ болжээ. Элронд, Арвен хоёр ширээнээс босч зоогийн танхимаас гарахад зочид араас нь дагав. Тэд өргөн хонгилоор явж, ил галын туяагаар гийгүүлэгдсэн дараачийн танхимд оров. Фродо эргэн тойрноо харснаа Гэндалф руу очлоо.

- Эльфүүд энэ танхимыг Ил галын танхим гэдэг юм. Одоо чи олон сайхан дуу, сонин түүх сонсоно... Унтчихгүй л бол шүү дээ. Энэ танхимын уур амьсгал сайхан бүүвэйлнэ гэж бод. Ердийн өдөр бол энэ танхим хоосон байдаг, Элронд өөрөө гал түлж, сайхан амарч, бодож сэтгэх гэж орж ирдэг. Энд тоотой хэдэн хүн л ордог юм гэж өвгөн шидтэн өгүүлэв.

Элронд өөрийнхөө суудалд сууж, эльф дуучид товшлуур хөгжмөөр тоглон дуулж эхэллээ. Танхимд зочид орж ирэн, Фродо эргэн тойрноо баяртайгаар харж, гайхалтай олон үндэстний төлөөлөгчид асар том задгай зууханд улалзан байгаа ил галын туяанд бүгд адилхан баяр хөөртэй, хөгжилтэй байхыг үзэв. Задгай зуухны дэргэдэх сийлбэрт баганы дэргэд гав ганцаараа суух хэн нэгнийг хараад Фродо өвчтэй юм байна гэж бодов. Тэр толгойгоо дэндүү бөхийсөн тул нүүр нь харагдсангүй, дэргэд нь аяга ус, зүсэм талхны өөдөс харагдана. Хөөрхий амьтан найранд орж чадаагүй юм байна гэж Фродо бодсоноо энэ оронд өвчин байдаг юм байх даа хэмээн гайхав.

Удалгүй дуу хөгжмийн эгшиг намдаж, Элронд босч ирээд задгай зуух руу дөхөв.

- Сэрээрэй миний бяцхан найз – гэж тэр хэлээд Фродо руу эргэж – Бэлтгээрэй, чиний аль хэдийнээс мөрөөдсөн мөч чинь одоо ирж байх шиг байна гэв.

Задгай зуухны дэргэд сууж байгаа этгээд хөдөлж, толгойгоо өргөн зочдыг тойруулан харав.

- Бильбо! – хэмээн баярласандаа бахардах шахсан Фродо хашгирлаа.

- Сайн явж байна уу, хүү минь. Чамайг Уудам хөндийд хүрээд ирж чадна гэж би мэдэж байсан – гээд Бильбо – өнөөдрийн энэ баярыг чамд зориулж байгаа юм. Чи ийм өндөр хүндэтгэл хүлээх гавьяатай. Зоог чамд таалагдсан гэж найдаж байна гэлээ.

- Мэдээж, таалагдалгүй яахав! – гэж Фродо дуу алдаад – Гэвч та яагаад дайллагад ороогүй юм бэ? Би яагаад одоо болтол таныг хараагүй юм бэ?

- Яагаад гэвэл чи унтаж байсан. Харин би чамайг өдөр бүр эргэж, Сэмтэй хамт орны чинь дэргэд сууж байсан. Дайллагын тухайд бол би сүүлийн үед найр, дайллагад хааяа л нэг ордог болсон, надад найрнаас илүү чухал ажил олон байна.

-Та юу хийж байгаа юм бэ?

- Суугаад л бодож сэтгэж байна. Энэ бол онцгой чухал ажил шүү дээ. Ил галын танхим бол

бодож сэтгэхэд дэлхий дээрх хамгийн тохиромжтой газар гэж би аль эрт мэдсэн юм... Бодлоос минь сэрээчихгүй л бол – гээд тэр Элронд харж “Сэрээрэй” гэнэ шүү, би унтаагүй байсан юм ноён Элронд. Та нар найраа эрт өндөрлөөд миний туйлын чухал бодлыг үргээчихлээ. Та нарыг орж ирэхэд би дуу зохиож, сүүлийн мөрүүдийг бодож байсан юм. Яагаад ч юм сүүлийн мөрүүд нэг л эвлэж өгөхгүй байсан юм, одоо хэзээ ч эвлэхгүй биз дээ. Эльфүүдийн дуу дэндүү гайхамшигтай гоё учраас би өөрийнхөө дууг ч мартчихаад байх юм. Надад ганцхан найдвар үлдлээ. Тэр бол Дунадан. Ингэхэд тэр хаана байна?

- Бид түүнийг заавал олж өгнө өө - гэж Элронд инээмсэглэн хэлээд – та хоёр аль нэг буланд хоёулхнаа ярилц, чи ч чухал бодлоо дуусга, тэгээд дараа нь бидэнд сайхан дуу дуулж өгөөрэй, бид дууг чинь өөрийнхөө дуутай харьцуулж үзье - гээд Элронд Дунаданыг олоод ир гэж тушаав. Дунадан хаана байгаа, яагаад энд хэрэг болсныг хэн ч мэдэхгүй боловч эрж олохоор болов.

Фродо өвгөн найзынхаа дэргэд сууж, Сэм хажууд нь зогсов. Тэд баяр баярын хөгжөөн, эльфүүдийн гайхамшигт дууг үл анзааран шуналтайяа ярьж гарав. Гэвч Бильбо сонсох сонин багатай байлаа. Тэр Хоббитанаас гараад харсан зүг рүүгээ явсан боловч нүд нь Уудам хөндий рүү харж, өөрөө эльфүүдийн дунд амьдрахыг хүсч байсан болж таарчээ.

- Би энд элдэв адал явдалгүй явж ирсэн. Хэсэг амраад найз гномуудаа эргэхээр явсан. Энэ бол миний сүүлчийн аялал байлаа. Хөгшин анд Балин хаа нэг тийшээ явсан байсан тул би гномууд дээр ирсэндээ харамсч билээ. Уудам хөндий намайг дахин дуудаж, би энд эргэж ирээд бүрмөсөн суурьшсан юм. Би чинь номоо дуусгах хэрэгтэй шүү дээ! Хааяа шүлэг бичдэг юм, эльфүүд ая оруулж дуулдаг. Гэхдээ хааяа нэг миний сэтгэлийг сэргээх гэж дуулдаг. Тэдний өөрсдийнх нь дуу минийхээс хамаагүй гоё л доо. Би Ил галын танхимд их суудаг, дэлхий ертөнцийн тухай, манай эрин үеийн тухай сэтгэдэг юм... энд сууж байхад цаг хугацаа урсаххаа больсон шиг санагддаг. Цаг хугацаа эльфүүдийг захирч чаддаггүй юм шиг...

Уудам хөндийн оронд бүх чухал мэдээ ирдэг боловч би Хоббитаны талаар юу ч сонсоогүй, зөвхөн бөгжний тухай сүүлийн үеийн мэдээг л авч байлаа. Гэндальф энд байн байн ирдэг, гэхдээ түүнээс их юм олж мэдэх биш. Тэр урьдынхаасаа ч дуу цөөтэй болсон. Харин Дунадан бага сага мэдээ дуулгадаг юм. Миний бөгж Дундад газарт тийм их түгшүүр төрүүлнэ гэж бодоход итгэмээргүй! Гэндальф түүний нууцыг их хожим тайлсан... эртхэн тайлсан бол бөгжийг олон жилийн өмнө ямар ч саад түйтгэргүйгээр хүргээд өгчих байсан юм. Би бөгжний хойноос дахиад явья гэж бодож үзсэн ч би хөгширсөн, эд нар намайг явуулаагүй. Дайсан газар сайгүй намайг хайж байгааг Элронд, Гэндальф хоёр сайн мэдэж байсан.

Гэндальф нэг удаа надад: “Бөгж одоо шинэ хадгалагчтай болсон Бильбо минь. Хэрэв тэр бөгж чамд эргэж ирвэл бид аймшигт их гай зовлонгоос зайлж чадахгүй” гэж хэлснийг санаж байна. Гэндальф дандаа оньсгоор ярьдаг шүү дээ. Гэхдээ тэр чамайг харж хандана, санаа тавина гэж хэлсэн болохоор түүний амлалтад итгэж найдаж байсан. Ингээд чи амьд мэнд хүрээд ирлээ... – гэснээ Бильбо гэнэт Фродо руу хачин хараад – Бөгж чамд байна уу? – гэж шивнэн асууснаа – Ийм олон гайхалтай үйл явдал болж өнгөрсний дараа би тэрнийг дахин нэг хармаар байна – гэлээ.

- Надад байгаа, яг л хуучин байсан хэвээрээ байгаа – гэж Фродо хэсэг дуугүй байснаа хэлэв.

Яагаад гэдгийг нь тэр өөрөө мэдсэнгүй боловч бөгжөө гаргаж ирэх маш дургүй байгаагаа мэдрэв. Тэгээд өвгөн найзаасаа харцаа бурууллаа.

- Гэлээ ч гэсэн би тэрнийг харахыг хүсч байна! – гэж Бильбо хэлэв. Өдөр нойрноос сэрээд Фродо хүзүүнд нь зүүлттэй байгаа бөгжийг тэмтэрч үзсэн билээ. Хэн нэг нь түүнийг унтаж байхад бөгжийг халааснаас нь аваад хүзүүнд нь зүүсэн байжээ. Маш нарийхан боловч бат бэх гинжээр зүүсэн байв... Фродо бөгжөө дургүйхэн гаргаж ирэв. Гэвч Бильбо түүн рүү гараа сунгахад Фродо айсан, уурласандаа давхийн хойш ухарлаа. Тэр мэл гайхав. Түүний найз Бильбо хаа нэг тийш алга болж, оронд нь үрчгэр хар нүүрт одой амьтан сууж байх бөгөөд нүд нь шуналаар дүрэлзэж, ясан гар нь чичирч байв. Тэр өөдгүй амьтныг цохиод авмаар санагдав.

Уянга төгс аялгуу гэнэт чихэнд чийртэй чихраад чимээгүй болов. Фродогийн чих шуугиж, шанааны судас нь хүндээр лугшаад явчихлаа. Бильбо түүний нүүр рүү харснаа чичирсэн гараараа нүдээ дарав.

- Одоо би ойлголоо – гэж тэр шивнээд – Бөгжөө далд хий, тэгээд болж өгвөл намайг уучлаарай. Энэ хүнд ачааг үүрч явсны төлөө намайг уучил. Чамд тулгарах аюул бүхний төлөө намайг уучил... Хар муу явдал хэзээ ч дуусахгүй юм гэж үү? Хэн нэгний эхэлсэн түүхийг өөр хэн нэгэн заавал үргэлжлүүлэх ёстой юм гэж үү? Тийм л юм шиг байна. Миний ном яах болж байна? Би түүнийг дуусгах хувьтай болов уу даа... Гэхдээ бие биеэ зовоохоо больё. Надад манай Хоббитаны тухай яриад өг. Одоо би өөр юуны ч тухай бодохыг хүсэхгүй байна!

Фродо санаа амарч бөгжөө далд хийв. Түүний өмнө дахиад л өвгөн найз нь үнэн дүрээрээ сууж байна, дуу хөгжим улам уянгатай болж, сайхан зочдын царайд баяр хөгжөөний туяа татан байна. Бильбо Фродогийн яриаг сэтгэл догдлон байж сонсов. Төрөлх Хоббитаны тухай ямар ч мэдээ, шинээр мод суулгасан тухай ч, сахилгагүй хүүхдийг хашраасан тухай ч түүнд асар их баярт мэдээ байлаа. Хоббитаны дөрвөн тойргийн тухай яриандаа автаад тэд элбэг хар ногоон цувтай өндөр хүн танхимд орж ирээд, тэдний дэргэд зогсон яриаг нь инээмсэглэн сонсч байсныг анзаарсангүй.

Арай гэж Бильбо түүнийг анзаараад:

- Энэ бол Дунадан гэж танилцуулав.

- Тэнэмэл! – гэж Фродо гайхсандаа дуу алдаад - Чи чинь олон нэртэй хүн юм аа!

- Энэ нэрийг нь харин би сонсоогүй юм байна – гэж Бильбо өгүүлээд – Яахаараа тэнэмэл байдаг билээ? – гэв.

- Уулын суурингийнхан намайг тэгж нэрлэдэг юм. Фродотой би Уулын сууринд уулзсан юм шүү дээ.

- Яагаад Дунадан гэж нэрлэсэн юм бэ? – гэж Фродо асуув.

- Арагорныг эльфүүд ингэж хүндэтгэн нэрлэсэн юм гэж Бильбо тайлбарлаад - Чи эльф хэлээ мартчихсан юм уу? Миний заасныг одоо сана. Дунадан гэдэг бол өрнийн Баатар ван гэсэн үг.

Гэвч одоо хичээл хийх цаг биш – гээд Бильбо дахин Арагорн руу эргэж - Чи хаана байв Дунадан, яагаад дайллага дээр байсангүй вэ? – гэж асуулаа.

- Бидэнд найрлаж хуримлах цаг бараг олддоггүй юм. Элладам, Элроир хоёр гэнэт хүрээд ирлээ. Тэр хоёр чухал мэдээ авчирсан болохоор би тэдэнтэй ярилцах хэрэгтэй байлаа.

- Тийм ээ, би ойлгож байна, найз минь - гэж Бильбо хэлээд – Гэвч чи тэдний мэдээг сонссон болохоор одоо надад жаахан цаг гаргаж чадна биз дээ? Чиний тусламжгүйгээр би амжихгүй нь. Элронд баярын төгсгөлд миний шинэ дууг сонсохыг хүсч байна гэсэн юм. Гэтэл би сүүлийн хэдэн мөрөн дээр гацчихаад байна. Хоёулаа нэг буланд суугаад миний дууг гүйцээе – гэв.

- Тэгье л дээ - гэж Арагорн инээмсэглэн зөвшөөрөв. Бильбо, Арагорн хоёр хаа нэг тийшээ явж, Сэм унтаад өгсөн тул Фродо ганцаараа үлдэв. Эргэн тойронд нь олон эльф байсан ч тэр ганцаардаж байгаа мэт санагдав. Эльфүүд түүнийг үл анзааран дуу хөгжимдөө хамаг анхаарлаа хандуулжээ. Хөгжим түр завсарласнаа дахин өөр дуу эхлэхэд Фродо ч бас чих тавин сонсов.

Эхлээд эртний сайхан аялгуу, хагас дутуу мэдэх хэлний шүлэг түүнд ихэд таалагдаж байсан ч сүүлдээ утгыг нь ойлгохоо болив. Бильбо Уудам хөндий рүү явахынхаа өмнө түүнд эльф хэл заасан билээ. Дууны үг ая харь холын орны тухай юм шиг, ил галын оч цацруулсан туяа ертөнцийн хязгаар дахь их тэнгисийн дээгүүр татсан алтлаг мананд шингэж байх шиг санагдав. Тэгснээ гэнэт нойронд автаж, эргэн тойронд нь урьд нь хэзээ ч зүүдэнд орж байгаагүй их давалгаан хөөсрөн мэлтэлзэх шиг.

Дараа нь зүүдний давалгаан дундаас дууны үг, аяын утга тодорч эхлэхэд Бильбо дууныхаа шүлгэнд ая оруулж байгааг мэдэв:

Эарендил хөлөг онгоцоо

Эртний Арверниэнд бүтээжээ:

Эцэсгүй Нимбретилийн эрэгт

Элшгүй хитгийг нь цавчжээ.

Энгүй мөнгөн торгоор

Их дарвуулаа нэхжээ.

Мөлтөршгүй шураг дээр нь

Мөнгөлөг гал асаажээ.

Хөлгийн хошуун дээр

Хөөрхөн хун урлаж

Хөхрөх давалгаан дээгүүр

Хос жигүүрийг нь дэлгэжээ.

Анхны хаадын удам тэрбээр

Алс өрнө зүг аялж явна.

Эртний рун бичээстэй

Илд хаах бамбайтай,

Гэрэл цацарсан хуягтай,

Гил хар эрчит сумтай,

Лууны нуруу мэт нумарсан

Лут мэргэн, хөнгөн нумтай,

Мана эрдэнийн хуйтай

Мөрөөдлийн ган илдтэй,

Гарьдийн өдөөр чимсэн

Ган төмөр дуулгатай,

Гал эрдэнийн тольтой.

Тэнгисийн чанад, уулсын орноо

Тэсгим мөсөн уулсын дэргэдүүр

Өрнөд туйлын туяан дор

Өмнө зүг рүү Эарендил хөвжээ.

Гэтэл шөнийн тэнгэрийн туяанд

Гүн харанхуйд залгиулсан

Гэрэлгүй хоосон эрэг зурсхийхэд

Гэнэт хөлгөө эргүүлж

Гэрийн зүг буцвай.

Хар салхинд туугдаж

Харанхуй манангаас зугтвай.

Тэгэхэд Эарендлийн хөлөг дээр

Тэнгэрээс Элвин бууж ирээд

Түүний дуулган дээр

Амьд эрдэнэ Сильмариллаа

Асааж гэрэл цацруулвай.

Тэгээд Эарендил хөлгөө эргүүлж

Тэр зүг рүү дахин одвой.

Хар салхи хөлгийг гүйцэж

Хараалт тэнгист аль эрт сөнөсөн

Хориот үхлийн ертөнц рүү нэвтэрвэй.

Эарендил цааш хөвсөөр

Эргийн хад нурахыг сонсов.

Эгц хавцалд хөөсрөх долгионд

Эрдэнэс, шижир алт гялалзахыг үзэв.

Алсад туузрах эргийн цаана

Үүлэнд умбасан уулс үзэгдэв.

Түүний цаана хязгаарын хязгаар,

Асар уудам хөндий дунд

Ариусан орон Илмарин оршвой.

Эльфүүдийн уугуул орон

Эртний цайз Трионы гал гэрэл

Зэрэглээт нуурын мандалд

Зүүд мэт гялалзаж харагдав аа.

Хавцлын дэргэд хөлгөө орхиод

Хадан даваагаар давгал

Хамаг эриний туршид нэг л хаан

Хэзээ ч үл мөхөх домгийн орныг

Хаанчилж өдгөө хүртэл захирчээ.

Ирсэн зочин хувцсаа сольж

Эльфүүдийн цагаан өмсгөлөөр гоёвой.

Эльфүүд хоригоо цуцалж

Эртний нууцыг түүнд тайлвай.

Хамгийн дээгүүр нөмөрсөн

Харанхуйн хар хүчинг

Гэгээн хүчний холбоо дарсан

Эртний түүхийг ярьж өгвэй.

Энд ч гэсэн Эарендилийг

Эрэлчийн заяа орхисонгүй:

Элберет түүнд Сильмариллаа

Эгнэгт дурсган өгвэй.

Эзэн хаан бас

Энэ ертөнцийг тойрон нис гэж

Эрдэнийн мөнгөн жигүүрийг

Эарендилд бэлэглэвэй.

Эарендил тэр орныг

Эгнэгт орхин тэнгэрт нисч

Эх нутгаа зоривой.

Эртний сар гэрэлтэж байгаа цагт

Эрдэнийн од нь асч байгаа цагт

Олон олон онд

Олон олон удаа нисч

Орчлонгийн нууцыг тайлжээ.

Аялгуут шүлэг ингээд төгсөв. Фродо нүдээ нээж эргэн тойрноо харав. Эльфүүд нүүр дүүрэн инээмсэглэн алга ташиж байна. Алга ташилт арайхийж дуусахад тэдний нэг нь:

- Одоо бид чиний дууг дахин сонсоно –гэв.

- Баярлалаа Линдир, гээд Бильбо босч, эльфүүдэд мэхийн ёслоод – гэвч дэндүү уйтгартай байх учир хэрэггүй биз дээ гэв.

- Чамд уу? – гэж эльфүүд инээлдээд – Чи өөрийнхөө шүлгийг уншихаас хэзээ ч залхаж байгаагүй шүү дээ! Дахин уншихаас нааш бид юун тухай шүлэг болохыг ойлгохгүй.

- Юу юу гэнэ ээ? – хэмээн Бильбо хашгираад – та нар миний ая данг Дунаданыхаас ялгахгүй байна уу?

- Бид үхэлт амьтдын уран бүтээлийг ойлгохдоо муу шүү дээ.

- Тэр дэмий, Линдир минь, та нарын сонсгол тийм муу гэхэд би итгэхгүй. Хүний бүтээл, хоббитын уран бүтээлийг ялгаж салгаж ойлгохгүй байна гэдэг бол алимыг вандуйнаас ялгахгүй байгаатай адил –гэж Бильбо ширүүлэв.

- Магадгүй л юм. Ногоочин ийм алдаа гаргавал уучилж болшгүй. Харин бидэнд өөрсдийн маань ажил маш их байгаа учир газрын үр шимийг харьцуулж суух зав алга.

- Маргаад яахав, ийм арвин дуу хөгжим намайг бүүвэйлээд бараг унтуулчихлаа. Би та нараар оньсого таалгасан, та нар дуртай бол таана, дургүй бол байна биз – гэж Бильбо хэлээд Фродо руу хүрч ирэв:

- Шүлэг минь миний бодсоноос илүү үр дүнд хүрэв бололтой. Эд нар дахиж уншихыг хүсэх нь ховор. Ямар ч гэсэн би хийхийгээ хийчихлээ. Юун тухай шүлэг болохыг тааж чадав уу?

- Би таах гэж оролдсон ч үгүй.

- Таах гэсний ч хэрэггүй. Бүх үг нь минийх. Дунадан ганцхан “эрдэнийн толь” гэдэг үг л нэмсэн юм. Яагаад ч юм түүнд энэ үг чухал санагдаж л дээ. Магадгүй тэр намайг дуугаа бичиж чадсангүй гэж бодсон ч байж болох... эсвэл Элрондын өргөөнд Эарендилийн тухай дуу

зохиох гэж барьж авсан л бол энэ зөвхөн миний хэрэг байж болох юм. Энэ тал дээр түүний зөв байх.

- Тийм юм шиг байна – гэж Фродо зөвшөөрөөд – гэхдээ би чиний дууг дүгнэж цэгнэж чадахгүй. Чи шүлгээ аялгуулан хэлж эхлэхээс өмнө би унтсан, дуу дуулж байгаа биш, зүүд маань үргэлжилж байгаа л юм шиг санагдсан. Би бүр төгсгөлд нь л чиний дуу хоолойг таньсан.

- Тийм ээ, хоббитуудын хувьд эльфүүдийн дуу дэндүү сайхан аялгуутай. Гэвч тэдний дунд амьдраад ирэхээр үүнд дасчих юм. Эльфүүд хэзээ ч дуу шүлгэндээ ханадаггүй, нэг л их сайхан хоол унд юм шиг. Тайван ярилцахад маань саад болохгүйн тулд эндээс гарцгаая.

- Тэд нар гомдох юм биш үү?

- Огт үгүй, энд хэнийг ч өөрийнх нь дураар байлгадаг. Хүссэн цагтаа орж, хүссэн цагтаа гарч, харин бусдын баяр баясгаланд бүү саад бол гэсэн зарчимтай.

Хоёр хоббит босч, бусдад саад болохгүйг хичээсхийн танхимын үүд рүү дөхөв. Жаргалтай инээмсэглэл нүүрэндээ тодруулан унтаж байгаа Сэмийг сэрээе гэж тэр хоёр бодсонгүй. Хаалгаар гарахын өмнө Фродо гунигтай эргэж харлаа, Бильботой ярилцах гэж тэсч ядан хүлээж байсан ч энэ танхимаас гарахыг хүсэхгүй байгаагаа ойлгов. Энд гайхалтай тайван, тохитой байлаа. Энэ үед дахин шинэ дуу уянгалав:

А Элберет Гилтониэль

Сереврен Рейна мириэль

А мэрель эглер Элленас!

На-кэард раллан дириэль

А галаареммин эннорас,

Фаруилос, ле линнатон

Нэф аэр, си нэф азарон!

Босгон дээрээс Фродо дахин эргэж харав. Элронд буйдан сандал дээрээ хөдөлгөөнгүй сууж, галын туяа түүний амгалан царайг нарны цацраг мэт алтруулж байв. Элрондын дэргэд Арвен сууж, хажууд нь Арагорн зогсч байна. Үүнд Фродо бага зэрэг гайхав. Цувныхаа юүдэнг арагш буулгаж, энгэрийг нь задгайлсан тул Арагорны цээжинд нэгэн тод од гялалзаж, хуягийг нь бүдэгхэн туяаруулан байв. Тэр Арвентай ямар нэг юм ярилцаж байсан бөгөөд Фродог эргэж харах агшинд Арвен түүн рүү эгцлэн ширтэв. Тэр харцыг мань хоббит насан туршдаа мартаагүй юм. Арвены харцанд хүлүүлсэн тэр хөдөлгөөнгүй зогсч, дууны үг ая тунгалаг булгийн шулганаан мэт...

- Явцгаая, эд нар дахиад зөндөө дуулна, Элберетийн тухай энэ дууны дараа Ариун газрынхаа

тухай дуулна – гэж Бильбо тэсч ядсан байртай хэлэв.

Хоёр хоббит хаалгыг болгоомжтой нээж, Бильбогийн жижигхэн өрөөнд орлоо. Өмнө зүг рүү харсан өрөөний цонхоор Бруинен голын хөндий харагдах агаад тэр хоёр өнгөрсөн үйл явдлуудыг дурсахыг хүссэнгүй, өмнө зүгээс аажмаар ойртож байгаа аймшигт хар үүлийн талаар бодохыг ч хүссэнгүй, цонхоо цэлийтэл нээгээд, өнөөдрийн баярт үйл явдал, Эльфүүдийн тухай, Уудам хөндийн гайхамшигтай сайхан цэцэрлэгийн тухай, одод, намуухан сайхан намрын тухай хөөрөлдөв...

- Өршөөгөөрэй, - гэж Сэм хаалга тогшин шагайгаад - Ямар нэг юм хэрэгтэй юу? – гэж асуув.

- Магадгүй чи Фродо бид хоёрт унтах цаг боллоо гэж сануулах гэсэн юм уу? – гэж Бильбо хэлэв.

- Уул нь ч унтах цаг болчихоод байна л даа – гэж Сэм санаа зовсон шинжтэй ч тов тод хэлээд – Маргааш өглөө эрт Зөвлөл хуралдана, шарх эдгэрээгүй байхад ингэж удаан суух дэмий биш үү?

- Чиний зөв өө - гээд Бильбо инээмсэглэж – Гэндальф руу явж очоод Фродо чиний үгэнд орж унтахаар явсан гэж илтгэх юм уу? - гэснээ Фродод хандаж – Сайхан нойрсоорой, дахин уулзсандаа би ямар их баярлаж байна вэ! Миний бодлоор, энэ ертөнцийн нэг ч амьтан Хоббитанаас ирсэн хоббит шиг тайван суугаад сайхан ярьж чадахгүй байх аа. Удахгүй бид дахин удаан хугацаагаар салж одно. Сүүлийн үед би их зөнөж байгаа болохоор чиний аяллын түүхийг миний номонд чи өөрөө оруулах байх даа гэж би айж байна даа. Сайхан зүүд зүүдлээрэй, миний сайн хүү минь! Би цэцэрлэгээр жаахан зугаална, Эльберетийн одыг хармаар санагдаад байна.

Бүлэг 14

Зөвлөл

Маргааш өглөө нь үүрээр сэрсэн Фродо сайхан амарч, бие хөнгөрсөн тул Бруинен голын эргээр зугаалмаар санагдав. Хувцаслаад цэцэрлэг рүү орж явахад алсын уулын орой дээгүүр тийм ч хурц биш том улаан нар хөөрч, агаарт намрын аалзны тор мөнгөрөн, навчис дээр шүүдрийн дусал гялтганан, голын дээгүүр өглөөн манан хөөрч байв. Сэм хажууд нь дуугүй алхаж, шүүдэрлэг агаарыг баяртайяа залгилаан, шинэхэн цасан дуулгатай алсын уулсыг гайхан харж байв.

Мушгиа замын нэг эргэлтийн цаана Бильбо, Гэндальф хоёр эргийн хаданд их л уртай засч хийсэн намхан чулуун сандал дээр суугаад ярилцаж байв. Бильбо инээмсэглэн:

- Өглөөний мэнд. Зөвлөл одоохон эхэлнэ гэж би бодож байна – гэв.

Одоохон гэв үү? - гэж Фродо лавлаад – Би жаахан зугаална гэж найдсан юмсан. Тэр нарсан ойд орохыг маш их хүсч байна! – хэмээн хөндийн хойд налууд бараантан байгаа төглийг заав.

- Зөвлөлийн дараа харанхуй болчихгүй бол зугаална биз дээ – гэж Гэндальф өгүүлээд – Гэвч тэгнэ ингэнэ гэж би урьдаас таамааргүй байна. Бид өнөөдөр олон зүйл хэлэлцэнэ – гэв.

Төдөлгүй шилтгээнд хонх жингэнэлээ.

- Элронд Зөвлөлийг дуудаж байна – гэж Гэндальф сандлаас босонгоо мэдээлээд - Бильбо, Фродо та хоёр хоёулаа уригдсан. Энд хожимдохыг зөвшөөрдөггүй, орцгооё.

Шидтэн замаар шилтгээн рүү алхахад Бильбо, Фродо хоёр араас нь дагаж, анхаарлын гадна үлдэж, жаахан гомдсон Сэм амандаа нэг юм бувтнаад араас нь дагав. Шатаар өгсч явахдаа Фродо эргэж харлаа. Нарлаг өглөө сайхан өдөр амлаж, голын урсгал намуухан шуугин, тэнгэрт шувууд жиргэж, түүнд тохиолдсон аймшигт явдлууд ертөнцийг нөмөрч байгаа хар үүлийн адил зүүд мэт санагдам тийм амгалан тайван, яруухан өглөө байлаа. Гэвч зөвлөлийн танхимд оруут л Элрондын урилгаар Зөвлөлд оролцож байгаа зочдын царай ер бусын түгшүүртэй, баргар байгааг ажиглав.

Фродо эхлээд Элрондыг, дараа нь Асалдар, Глоиныг харлаа. Танхимын нэг буланд гандмал цуваа өмсч баргар царайлсан Арагорныг харав. Бусдыг нь Фродо танихгүй ажээ. Элронд түүнийг дэргэдээ суулгаад, хурсан зочдыг тойруулан харсны дараа:

- Холын Хоббитан орноос ирсэн Бильбогийн үеэл дүү Фродог танилцуулахыг зөвшөөрнө үү. Түүний туулж ирсэн зам амаргүй болоод аюултай байсан, Уудам хөндийд тэр тулалдаж байж орж ирсэн – гэв.

Дараа нь Элронд Фродогийн анх удаа харж байгаа зочдыг танилцууллаа. Танхимд Глоины хүү Гимли, Мөнгөлөг боомтоос ирсэн эльф Гэлдор, Умард Балар шугуйн эльфүүдийн ван

Трандуилын хүү эльф Леголас, Элрондын зөвлөх эльфүүд, түүний дотор ахлах зөвлөх Эрестор сууж байгаа ажээ. Эдгээр зочдоос жаахан зайдуу ширээнд гоо сайхан, буянтай мөртөө эрэлхэг баатарлаг царайтай, ширүүн харцтай, хар үстэй өндөр хүн сууж байна.

Түүний удаан хугацаагаар хайч хүрээгүй үс мөр рүү нь замбараагүй буржийн унаж, энгэрт нь зүүлттэй сувдан шигтгээтэй мөнгөн зүүлтийг нь халхлах бөгөөд мөрөндөө анчны мөнгөн чимэгтэй эвэр бүрээ бүхий мөрөвч углажээ. Тоосонд сааралтаж, шавар наалдсан, морины хөлсөнд гөлгөр болсон тансаг хувцас алс холоос амаргүй зам туулж ирснийг нь харуулж байлаа. Тэрбээр Фродо, Бильбо хоёрыг гайхан харж байв.

- Энэ бол Боромир – гэж Элронд түүнийг танилцуулаад - Өмнөд нутагт оршин суудаг хүмүүсийн элч. Тэр дөнгөж өнөө өглөө ирсэн, түүний ард түмэнд тулгарч байгаа аюул нийт Дундад газарт ойртож байгаа аюултай нийтлэг учир би түүнийг Зөвлөлд оролцохыг урьсан юм гэв.

Элрондын зөвлөл дээр ярилцсан бүх асуудлыг манай түүхэнд оруулах шаардлагагүй билээ. Эхлээд Фродо огт сонсоогүй Хязгаар газрын тухай ярьж байсан учир илтгэгчдийг төдийлөн анзаарсангүй.

Тиймээс тэдний яриаг сонсч байгаа дүр үзүүлээд л сууж байв. Гэвч Глоин ярих ээлж болоход чих тавин сонсов. Учир нь Даяны шадар туслахуудтай Бильбо нөхөрлөж байсан билээ. Уулын хаант улс хар айдсыг амсч эхлээд байгаа ажээ.

- Олон жилийн өмнөөс бид өөрчлөлт, шинэчлэл хийж эхэлсэн – гэж Глоин үгээ эхлээд – Бүх юм анзаарагдамгүй, аяндаа эхэлсэн. Хэдэн гном Гоонь ууланд амьдрах орон зай бага боллоо, арай удам газар олж авахад юу нь буруу муу байх вэ гэж бодож л дээ. Тэгээд Мори буюу манай гномуудын хэлээр бол Казад-Дум, өөрөөр хэлбэл эцэг өвгөдийн хөдөлмөрөөр буй болсон газар нутгийн тухай яриа болжээ. Олон гном уугуул газар нутагтаа буцах цаг болсон гэж л дээ.

Мория!.. – гэж хэлээд Глоин гунигтайяа санаа алдаж – Умард хязгаар дахь гномуудын мөрөөдлийн орон! Бидний өвөг дээдэс эд баялаг, алдар нэрд дуртай байсан, тэд уулсын хэвлийг уудалж, үнэт эрдэнийн чулуу, өнгөт металл олборлон түүндээ шунаж улам гүн ухсаар ёроолгүй их галд булшилсан Айдсыг гаргаад иржээ. Гномууд Моригоос зугтсан боловч тэр газар орныг айдас хүйдэс, эргэж очих нууцхан горьдлого тээн дурсдаг байжээ. Гэвч олон үе солигдож, эцэг өвгөдийнхөө эх нутаг руу эргэж очих зоригтон төртөл олон үе элээсний дараа Трор анх зориглон хөдөлж, Казад-Думд очоод үүрд алга болсон юм. Гэтэл тийшээ Балин хөдөлсөн. Даян хаан түүнийг явуулахгүй гэсэн боловч тэр Ори, Оин зэрэг олон зоригт гномуудыг дагуулан гарсан юм.

Энэ бол гучин жилийн өмнөх явдал. Эхлээд Балиныг азын тэнгэр ивээж тэд эртний эзэнт улсад ороод, орхигдсон орон оромжоо сэргээсэн тухай Балины элч ярьсан юм. Гэвч тэр цагаас хойш Балины тухай ямар ч мэдээ сонсогдоогүй...

Дараа нь нэг жилийн өмнө Даян хаанд бас нэг элч ирсэн, гэхдээ Балинаас биш холын Мордор орноос ирсэн. Тэр элч харанхуй шөнөөр, хар морьтой ирээд Даян хааныг харуулын цамхагт

дуудаж, манай эзэн агуу Саурон гномуудтай холбоотон болохыг хүсч байнагэж мэдээлээд, хэрэв та нар хоббитуудын талаар тодорхой мэдээлэл өгвөл бид шидэт бөгжийг чинь буцааж өгнө гэж амласан. “Тэр бөгжнүүдийн нэгийг чи огт мэдэхгүй гэдгийг агуу Саурон мэдэж байгаа” гэж тэр элч хэлжээ.

Даян хариу хэлэх үгээ олохгүй байтал Сауроны элч “Агуу хүчирхэг эзэн Саурон чамд ирээдүйн найрамдлын тэмдэг болгож тэр муу жижиг хулгайчийг олоод хэрэв нэгэн цагт хулгайлсан тэр бөгжөө өгөхгүй бол булааж авна гэж дамжуул гэсэн. Тэр бөгж ямар ч үнэгүй боловч агуу Саурон чамайг хэр зэрэг итгэлтэй холбоотон бэ гэдгийг үүгээр сорьж байгаа юм. Хэрэв чи агуу эзний зарлигийг биелүүлбэл тэр чамд эрт цагт гномуудад байсан гурван бөгжийг буцааж өгнө, Мори орныг ч өгнө. Хэрэв чи тэр хоббитыг дийлэхгүй бол ядаж хаана байгааг нь хэлж өг. Тэгвэл чамд өгөөмөр их шагнал өгнө. Харин агуу Сауроныг хуурах гэж оролдвол уу” гэж тэр элч занажээ.

Элч сүүлчийн үгээ хэлэхдээ гэнэт могой болж хувирсан мэт хачин муухай исгэрч хэлсэн тул цамхгийн хамгаалагч дайчид цочин сандарсан боловч Даян хаан:

- Би чамд шууд хариу хэлж чадахгүй. Би чиний хэлснийг бодох хэрэгтэй байна гэхэд элч:

- Бод бод, гэхдээ хэтэрхий их цаг хий дэмий битгий үр – гэж илэрхий заналхийлсэн байртай хэлэв.

- Би өөрийнхөө цагийг өөрөө мэднэ – гэж Даян хааны сүрээ алдалгүй хэлэхэд:

- Одоохондоо – гэж элч амандаа хэлчихээд яваад өгөв.

Тэр цагаас хойш айдас түгшүүр биднийг нөмөрсөн. Сауроны элчийн үг хэл бал мэт амттай байсан ч бид тэртэй тэргүй айж түгших байсан: Сауроны ямар ч санал аюул занал агуулж, итгэл эвдэж байдаг. Мордорын өсөн нэмэгдэж байгаа хүч чадал түүний хатсан үндсийг тэжээгээгүй боловч мөн чанар нь хэвээрээ байгаа гэдгийг бид мэднэ... Сауроны элч хоёр удаа ирсэн ч хариу авалгүй буцсан. Тэр энэ оны эцсээр сүүлчийн удаа хариу авахаар ирнэ гэсэн.

Би Бильбог Дайсан шургуу хайж байна гэж сэрэмжлүүлэхээр Уудам хөндийд ирсэн юм. Түүнээс гадна ямар ч үнэ цэнэгүй юм шиг тэр бөгж яагаад Дайсанд хэрэг болсныг мэдэх гэж ирсэн. Бас Даян хаан Уудам хөндийн орны эзэн хаанаас зөвлөгөө аваад ир гэж даалгасан, энэ аюулын хар сүүдэр биднийг адилхан нөмөрч байгаа шүү дээ. Нуурын улсын хаан Брандад Сауроны элч ирж, бас тулган шаардлага тавьсан, Бранд маш хүнд байдалд ороод байгаа тухай дөнгөж саяхан бид мэдсэн. Тэр орны зүүн хил дээр дайн эхлэх нь нэгэнт тодорхой болчихоод байна. Хэрэв элчид нь хариу хэлэхгүй бол Саурон хар цэргээ Даян хааны эсрэг, Бранд хааны эсрэг хөдөлгөнө. Бранд нөмрөн ирж байгаа аюулаас айж байгаа учраас хар эзэнд захирагдаж магадгүй байна.

- Чи цагаа олж иржээ – гэж Элронд хэлээд – Дайсан ямар бөгж хайж байгаа нь өнөөдрийн Зөвлөгөөнөөр чамд тодорхой болно. Чи бас амьдралын төлөө биш, үхлийн төлөө, ялна гэсэн найдваргүйгээр Дайсантай тулалдахаас өөр зам танайд байхгүй гэдгийг ойлгоно. Дундад газарт ганцхандайсан бий. Харин бөгжний тухайд бол... Ямар ч үнэ цэнэгүй юм шиг тэр

бөгжийг яах вэ гэдгийг бид өөрсдөө шийдэх ёстой болоод байна...

Шийдэх ёстой болоод байна гэж би хэллээ, гэхдээ би та нарыг Уудам хөндийд дуудаагүй. Та нар өөрсдөө ирсэн, яг зэрэг ирсэн, тэгэхлээр та нарын энэ уулзалтыг тохиолдлын гэж хэлэх аргагүй. Та нар бөгжний оньсогыг таагаад дундад газрын хувь заяаг эцэслэн шийдэх ёстой.

Тийм учраас бид бөгжний нууцыг нээж байна. Юуны өмнө түүхийг нь ярья. Би эхэлнэ, бусад нь гүйцээнэ.

Элрондын тайван бөгөөд тов тод дуу хоолойг уригдсан зочид цөм сонсов. Элронд шидэт бөгжнүүдийг давтсан хоёр дахь эриний тухай, эртний Мордор орны эзэн Сауроны тухай ярилаа. Энэ түүхийн зарим зүйлүүдийг олон зочин мэддэг байсан боловч бүрэн бүтнээр нь мэддэг хүн нэгээхэн ч үгүй байсан тул зочид Остраннд амьдарч агсан эльф дархчуудын тухай, тэд Морийн гномуудтай дотно нөхөрлөдөг байсан тухай, тэд эрдэм мэдлэгт хэрхэн тэмүүлдэг байсан тухай, Саурон хуурамч анд нь болж тэдэнд тусламж амласан тухай, эльф дархчууд тэр саналыг хүлээн авч гайхамшигт бүтээлүүдийг урласан, Саурон тэдний бүх нууцыг мэдэж аваад Мордор оронд байх Галт уулын оргил дээр бусад бүх бөгжийг захирах Бүхний эзэн бөгжийг давтсан. Гэвч эльф Селебримбэр энэ тухай мэдээд түүний хийсэн гурван бөгжийг нууснаас үүдэн цус урсгаж, бүгдийг цөлмөсөн дайн дэгдсэн, ингээд Морийн эзэнт улсын үүд хаалга хаагдсан юм.

Элронд бүхнийг захирагч тэр бөгжийг хэрхэн мөрдөж байснаа товчхон яриад, энэ түүхийг хэн бүхэн мэдэх учир ярих шаардлагагүй гэлээ.

Дараа нь Элронд Нуменоре орны тухай, тэр гүрэн яаж мөхсөн тухай, их ард түмний хаад эргэж ирсэн тухай, агуу их хаан Элендилийн тухай, түүний хүү хоёр их улсыг байгуулсан хаад Исилдур, Анагрион хоёрын тухай ярилаа. Саурон тэр хоёр улстай дайтахад ах дүү хоёр хаан эльфүүдээс тусламж эрж, хүмүүс ба эльфүүдийн хооронд холбоо байгуулсан тухай ярилаа.

Элронд нэгэнтээ санаа алдаад яриагаа үргэлжлүүлэв:

Элендила, Гил-Гэлад хоёрын нэгдсэн хүч Арнорт нийлж, Мордор руу дайлаар мордоход би энэ их хүч Тонгородримийн харанхуй хар хүчийг ялсан анхдугаар эриний нэгдсэн их нөхөрлөлтэй ижил юм байна гэж бодсон, тэгээд эльфүүд дайсныг дарчихлаа гэж бодсон, гэвч энэ бол аймшигтай эндүүрэл байлаа...

- Чи тэгж бодож байсан гэж үү? – ихэд гайхсан Фродо асуугаад – Анхдугаар эрин гэдэг чинь аль тэртээ балар эртний үе гэж би боддог байсан юм –гэлээ.

- Тийм ээ, гэхдээ би тэр бүгдийг сайн санаж байна... Миний эцэг бол Гондолины эзэнт гүрний уугуул Эарендил, миний эх бол Дориатын орны Лучиэний хүү Диорын охин Эдвин. Би Газар дундын орны гурван эриний амьд гэрч, Дайсны эсрэг үй олон тулалдаанд оролцож явсан эльф...

Би Гил-Гэладын зарч байсан, Дайсныг бут ниргэсэн Мордорын хаалганы дэргэдэх тулаанд оролцож байсан, учир нь Гил-Гэладын жад Айглос, Элендилийн илд Нарсилтай тэнцэх

зэвсэг Дайсанд байгаагүй юм. Би Галт уулын дэргэд ч тулалдаж байсан, тэр тулаанд Гил-Гэлад амь үрэгдэж, Элендил ч бас дайсны дуулганд илдээ хугалаад амь үргэдсэн, бүхнийг захирагч бөгжийг эзэмшиж байсан Исулдур Сауроныг устгасан.

- Тэгэхлээр тэр бөгж одоо байгаа байх нь ээ? Манай домгоор бол хоёр дахь эриний төгсгөлөөр тэр бөгж алга болсон байх ёстой. Гэтэл түүнийг Исилдур эзэмшиж байж ээ?

- Тийм ээ эзэмшиж байсан, уул нь тэгэх хэрэггүй байсан юм. Бөгжийг тэр үед анх давтсан Галт ууланд устгах байсан юм. Гэвч Исилдур бөгжийг авч үлдсэн. Үүнийг зөвхөн Сэрдан бид хоёр л харсан. Бусад дайчид бүгд амь үрэгдсэн байлаа. Бид хоёр Исилдурт анхааруулсан боловч тэр бидний үгийг аваагүй.

“Миний эцэг, ах хоёр тулаанд амь алдлаа, би энэ бөгжийг шударга тулаанаар ялж авсан, би тэднийхээ дурсгал болгож энэ бөгжийг авна” гэж тэр хэлсэн. Гэвч тэр бөгжний гайгаар Исулдур амь үрэгдсэн, харанхуйн эзний хий үзэгдэл болсноос тэр нь ч дээр байлаа. Энэ тухай зөвхөн умардынхан бид болоод Исилдурын амь үрэгдсэн Наём газрын цөөхөн хүн мэднэ. Ердөө гуравхан хүн эргэж ирсний нэг нь Исилдурын зэвсэг хадгалагч Охтар байсан, тэр Элендилийн илдний хугархайг авчирч Исилдурын хүү Валендилд өгсөн. Валендил Уудам хөндийд өссөн, харин Нарсиль илдний хоёр хугархай л үлдсэн, түүнийг дахиж давтаагүй.

Би Дайсныг ялаад ч хэрэг болоогүй гэж хэлэв үү? Бүрэн ялалт биш байсан гэж хэлбэл ононо. Саурон ялагдсан ч гэсэн амьд үлдсэн, бөгжөө алдсан боловч тэр бөгж одоо ч байгаа. Мордор дахь хар цайзыг газартай тэгшилсэн боловч суурь нь үлдсэн, бүхнийг захирагч бөгжийг устгаж, гай зовлонгийн үндсийг таслахаас нааш Дайсныг бүрэн ялах боломжгүй. Дайнд олон хүн, олон эльф амиа алдсан. Исилдур, Анарион, Элендил, Гил-Гэлад тэдний бүх баатрууд. Тэр үеийн холбоог сүүлчийн холбоо гэж нэрлэсэн нь зүгээр нэг сүржин үг биш. Дэлхий дээр үхэлт амьтад улам болон болж байна, хүн бүрийн амьдрал богиносч байна, ууган төрөлт мөнх настнууд улам цөөрч байна, бид бие биеэ ойлгоход бэрх болж байна.

Гондорын хаант улс хараахан мөхөөгүй, эхлээд эртний Нуменор гүрний адил өсөн бэхжиж, цайз бэхлэлт, цамхаг харшууд нь алс холд ч алдаршиж байсан. Гондорын нийслэл Одот Осгилиат Андуин мөрний эрэгт баригдсан. Нэгэн цагт Исилдурын харь газраас авчирсан цагаан модны үрийг тэр мөрний эрэгт суулгасан. Хорин жилийн дараа тэр үр агуу хүчирхэг, асар том мод болж ургасан. Нийслэл хотын өмнө талд Минас-Итил буюу мандах сарны цайз боссон, баруун талд нь Цагаан уулнаа Минас-Анор буюу Жаргах нарны цайз боссон.

Гэвч бүхнээс хүчтэй цаг хугацааны хүйтэн амьсгал Гондорын хаант улсын алдар цууг бүдэгрүүлэв. Цагаан мод өмхрөн хатаж, Анарионы хүү Менельдил ван угсаа залгамжлагч төрүүлэлгүй нас барсан, нуменорын хаадын удам тасарсан. Дараа нь Мордорыг хамгаалж байсан харуулынхан нэгэн шөнө харанхуй нойронд автаж, харанхуй хар хүчнүүд чөлөөтэй болоод Горгоротын өндөр хананы цаана нуугдсан, түүнээс хойш удаа ч үгүй байтал бас л шөнийн харанхуйгаар Мандах сарны цайзыг эзэлж, хавь ойрын бүх хүн амыг хүйс тэмтэрч, Минас-Итилиг Минас-Моргул буюу Хар хүчний цайз гэж нэрлэсэн. Гондорын хүмүүс баруун тийш ухарч, Жаргах нарны цайзад орж суусан бөгөөд түүнийг Минас-Тирит буюу Сүүлчийн найдварын цайз гэж нэрлэсэн. Хоёр цайзын хооронд дайн дэгдэж, Осгилиат хотыг үнсэн товрог болгон, түүний нурангид өдөр ч, шөнө ч нүдэнд үл үзэгдэх үнс сүгнүүд

орогносон.

Олон үе солигдож, дайн үй олон амь залгисан ч Минас-Тирит тэмцсээр байсан, Дайсан Андуин мөрний наана гарч чадаагүй, Чулуун аваргуудаас тэнгис хүртэлх зам харьцангуй аюул багатай гэж тооцогдож байсан. Ингээд миний ярих зүйл дуусч байна. Исилдур нас барсны дараа бүхнийг захирагч бөгж ор мөргүй алга болж, гурван бөгж чөлөөтэй болсон. Гэвч одоо тэр гурав бас л аюулд ороод байна, өөрөөр хэлбэл бүгдийг захирагч бөгж гараад ирсэн.... Гэвч энэ тухай та нарт бусад зочид ярьж өгнө, би сүүлийн үеийн үйл явдлуудад оролцоогүй.

Элронд яриагаа дуусмагц Боромир босч ирэв:

- Эрхэм хүндэт Элронд, Гондорын тухай чиний яриаг үргэлжлүүлэхийг надад зөвшөөрнө үү, яагаад гэвэл гондорчууд намайг Уудам хөндий рүү илгээсэн, тиймээс зочид тэднийг ямар аюулаас бид хамгаалж байгааг мэдэхэд илүүдэхгүй. Надад итгээрэй, өмнөдийн нуменорууд устгагдаагүй, Гондорын алдар суу мартагдаагүй. Бид дангаараа Дайсны хүчний түрэлтийг тогтоон барьж, баруун газрыг Моргулаас хамгаалж байна. Хэрэв дайснууд Андуиныг гатлаад ирвэл баруун газарт юу болохыг төсөөлж байгаа биз дээ!

Энэ аюул эргэлт буцалтгүй наашилсаар байна. Харын хүч улам нэмэгдсээр байна. Танайхны Галт уул гэж нэрлэдэг хараалт Ородруин дахин утаа савсуулж байна! Мордорын хүчин чадал олон дахин нэмэгдсэн болохоор биднийг хар хөшиг хааж байна. Дайсан цайздаа эргэж ирэнгүүт бид Андуин мөрний зүүн эрэгт Итилийн түшиц цайзын хамгаалалтад байсан Итилийн газрыг алдсан. Энэ оны зун зургадугаар сард Мордорын хар тугийн дор нэгдсэн асар их хүч манайх руу довтолсон, бид мөрөн рүү ухрах хэрэгтэй болсон. Дайсан биднийг тооны олноор дийлэхгүй боловч тэдэнд ямар нэг далдын хар хүчнүүд үйлчлээд байна.

Тэд шөнийн харанхуйг өтгөрүүлсэн юм шиг хар морьтнууд болж гарч ирдэг, тэд тулаанд орохоор холбоотнууд нь галзуу мэт улайран дийлдэмгүй болдог, хар морьдыг үзэнгүүтээ манай дайчдын морьд эргэж зугтаадаг, дайчид сандарч, мориныхоо жолоог эргүүлж чадахгүй болдог юм. Мөрний зүүн эрэгт болсон сүүлчийн тулалдаанд гондорчуудаас хэдхэн зуун дайчин үлдсэн, тэд мөрнийг гатлан ухрахдаа гүүрийг нураасан, тэр бол сүйрсэн Осгилиатын сүүлчийн ганц гүүр байсан юм. Ухрах үед хамгаалж байсан дайчдын багийг гол руу шахаж хайр найргүй устгасан.

Тэр багт тулалдаж байсан дайчдаас би болон миний ах дүү дөрвөн дайчин, бас дийлдэшгүй их хүчит хоёр дайчин л амьд үлдэж Андуиныг сэлж гарсан...

Одоо бид баруун эрэгт бэхлэлт барьсан, дайснууд мөрнийг гаталж чадахгүй байгаа, манай умард болон баруун талын хөрш улсууд энэ дайны тухай мэдээд бидэнд халуун баяр хүргэж байгаа ч гэсэн одоо болтол туслах хүч ирүүлээгүй байна... Манай хаан хөрш улсуудаас тусламж хүсэхэд зөвхөн Мустангримүүд л хариу өгсөн.

Энэ бэрх үед би алс холын Уудам хөндийг зорьсон билээ. Би аль эрт мартагдсан нууц жимээр олон зуун лиг газрыг туулж, аян замд нэг зуун арав хоног өнгөрүүлэв. Гэхдээ би цэргийн тусламж өгөөч гэж гуйхгүй, харин Элрондын цэцэн мэргэн ухаан домог болсон учир би

зөвлөгөө... тэр ер бусын хар шидийн нууцыг тайлах зөвлөгөө авахыг хүсч байна. Учир нь зургадугаар сарын тулалдааны өмнөхөн миний дүү бид хоёр нэг шөнө ив ижилхэн зүүд зүүдэлсэн юм.

Бид хоёр зүүдэндээ тэнгэрийн дорно хагас харанхуйлж, тэнгэрийн хаяанаас цаана аянга нижигнэж байхад тэнгэрийн баруун хагаст жаргах нарны улаан туяан доогуур тод цэнхэр туяа татаж, нэгэн тод дуу хоолой аяархан ингэж шүлэглэсэн юм:

Амиа ч мартсан энэ тулаанд Элендилийн

Амин хайртай илд хугарчээ.

Харин Исилдур тэр тулаанаар

Хараал шингээсэн олз олжээ.

Хараалт тэр олзыг

Харах зоригтон үгүй ч гэсэн

Хааны хугархай илдийг

Имладрист давтаж байна.

Дүү бид хоёр энэ хачин шүлгийн утгыг ойлгоогүй боловч Гондорын хаант улсын тэргүүн захирагч, Дундад газрын эртний түүхийн нэвтэрхий толь болсон Денэтор ааваасаа асуугаад өнө эртийн цагт хойт зүгт мэргэн жолоодогч Элрондын үндэслэн байгуулсан эльфүүдийн орныг Имладрис гэж нэрлэдэг байсныг л мэдэж авсан юм. Гондорын ард олонд сүйрэл нүүрлэж байгааг бид хэн хэнгүй мэдэж байна. Тиймээс ч миний дүү бид хоёр ирээдүйг харсан мэргэн зүүд зүүдэлсэн учир Элрондыг эрж олоод зүүднийхээ нууцыг тайлъя гэсэн юм. Хойт зүгийн зам аюултай тэр замаар хэн ч явахаа болиод удсан боловч би нууц жимүүдийг мэдэх учир би дүүтэйгээ энэ их замд гарсан юм. Аав минь бид хоёрыг явуулах дургүй байсан, бид хоёр умард нутгаар олон хоног аялсан, учир нь Элрондын тухай олон хүн сонссон боловч хаана амьдардгийг нь мэдэхгүй байсан. Гэлээ ч гэсэн би зөв замаа олж, Имладрист хүрээд ирлээ.

- Энэ танхимд ч гэсэн чамд олон нууц тайлагдана – гэж Арагорн яаралгүй босонгоо хэлээд Элрондын өмнөх ширээн дээр дундуураа хугарсан илд тавихыг бүгд харав.

- Хааны хугархай илд чинь энэ байна даа!

- Чи хэн бэ? Чи Гондор оронтой ямар хамаатай юм бэ? – гэж туйлын их гайхсан Боромир асуугаад түүний өнгөө алдтал гандсан цув, эцэж турсан царайг нь ширтэв.

- Энэ бол Араторны хүү Арагорн – гэж Элронд аяархан хариулаад – Итил цайзын эзэн Исилдурын холын боловч ойрын удам, нуменорын үр удмынхан буюу умардын дунаданчууд Арагорныг удирдагчаа гэж үздэг юм.... Харамсалтай нь тэднээс цөөхөн хүн үлдэж дээ.

- Тэгэхлээр бөгж чамд хамаатай байх нь ээ? – гэж дуу алдаад Фродо үсрэн босч айсан ч юм шиг, санаа нь амарсан ч юм шиг асуув.

- Тэр чамд ч хамаагүй, надад ч хамаагүй, гэвч хувь заяаны эрхээр чи түүний хадгалагч болсон гэж Арагорн тайван мөртөө жинтэй хэлэв.

- Цаг нь боллоо. Бөгжийг үзүүл. Боромир зүүдээ зөнч мэргэн байсан гэдэгт нүдээрээ итгэг! – гэж Гэндальф Фродод хэлэв.

Танхимд нам гүм болж, хүн бүхэн Фродо руу нүд цавчилгүй харах бөгөөд Фрода ихэд сандарч, нэг л хачин айсан царайтай, бөгжийг үзүүлэхийг хүсэхгүй байгаагаа, түүнд гар хүрэхэд ч хэцүү байгааг мэдрэв. Гэвч өөрийгөө ялж, чичирсэн гараараа бөгжийг гаргаж ирж чадлаа. Нэг бүдгэрч, нэг тодрон гялалзах бөгж бүхний анхаарлыг татлаа.

- Исилдурын авсан хараалт эд чинь энэ дээ – гэж Элронд хэлэв.

- Тэгвэл Гондорын ард түмний эцсийн найдвар талаар болсон хэрэг үү? Тийм юм бол бидэнд хугархай илдний хэрэг юун билээ? – гэж Боромир бөгжийг өргөн харуулж байгаа Фродогоос асуув.

- Чи ойлгосонгүй. Цаг боллоо, тэгэхдээ энэ бол МинасТиритийн эцсийн цаг биш! – гэж Арагорн тайвнаар хэлээд – Гэхдээ үхэх сэхэхээ үзэх цаг, энэ цаг биднийг агуу их үйл хэрэгт дуудаж байна.

Хугарсан илд Элендилийнх байсан, түүний удмынхан түүний юуг ч үе дамжуулж хадгалаагүй мөртөө энэ илдийг нандигнан хадгалж ирсэн, учир нь Исилдурын хараалт эдийг эрж олсон цагт эцэг өвгийнх нь илдийг сэргээн давтаж болно, тэр илд дайсныг дарах хараал болно гэж эртний арнорчууд мэдэж байсан юм. Тэгэхлээр чи Элендилийн залгамжлагч Гондорын дайчдад туслахаар хөдлөхийг хүсч байна уу?

- Би зөвлөгөө авах гэж ирсэн, тусламж гуйх гэж ирээгүй. Гэвч Гондорт хүнд сорилт тулгарсан болохоор бид Элендилийн илднээс татгалзаж чадахгүй... хэрэв нэгэн цагт оргүй алга болсон зүйл дэлхий дээр дахиад ирдэг нь үнэн бол бид тусламжийг хүлээж авна гэж Гондорын элч үл итгэсэн янзтай өгүүлэв.

Боромирын эргэлзээ Бильбогийн уурыг хүргэж байгааг Фродо мэдэрч байлаа. Тэр гэнэт ухасхийн босоод:

Эртний алт гялалзах нь ховор

Эртний илдний үзүүр содон

Эрүүлч ноён тулаанд гарна:

Эрийн цээнд хүрнэ гэдэг

Элж өтлөхийн нэр биш.

Гай зовлон домог болно,

Гал мэт илд дахин улалзана,

Ноёны нэрийн өмнөөс

Ноёныг ноёноор нь дуудна гэж уншаад:

- Магадгүй энэ шүлэг тийм ч уянгатай уран сонсогдохгүй байж болно, гэхдээ л чиний нууцлаг зүүдний учрыг тайлж өгөх байх – гэж Бильбо өгүүлээд – Хэрэв чи Элрондын тайлбарыг сонсох гэж таван зуун лиг зам тулж ирчихээд тайлбарыг нь сонсохгүй байгаа бол энэ шүлэг тайлж өгнө... хэмээн ёжтой хэлээд суудалдаа суулаа.

- Дунадан надад өөрийнхөө тухай ярьж өгсний дараа би энэ шүлгийг өөрөө зохиосон юм. Одоо аяллаа дуусгасандаа бараг харамсч байна. Тиймээс Дунадантай хамт тийшээ явж, тэр үүргээ яаж биелүүлэхийг нь харж чадахгүй нь – гэж тэр Фродод шивнэв.

Арагорн Бильбогийн яриаг инээмсэглэн сонсоод Боромирт хандаж:

- Итгэхгүй байгааг чинь би уучилъя. Би Исилдур болон Денэторын гэрт чиний харсан эцэгтэй нь огт адилгүй харагдаж байгаагаа мэдэж байна. Би бол агуу Исилдурын шууд удам, гэхдээ удам нь болохоос Исилдур биш. Би их урт амьдрал туулсан. Уудам хөндийгөөс Гондор хүртлэх тэр хэдэн зуун лиг бол миний амьдралдаа туулсан их замын өчүүхэн хэсэг гэдэгт итгээрэй. Би олон гол мөрөн гаталж, олон уул даваа давж, бидний мэдэхгүй одод гэрэлтдэг олон улс орныг үзсэн...

...Гэхдээ умард нутгийг өөрийн эх орноо гэж үздэг юм. Энэ газарт Валендил вангаас хойш миний бүх өвөг дээдэс төрж, өсч, өтөлж, өөд болцгоосон. Арнорчууд амаргүй амьдрал туулсан боловч үеэс үед, ааваас хүүд бидний агуу хүчирхэг явсны дурсгал энэ илдийг өвлөн хадгалж ирсэн юм.... Бас өөр нэг юм чамд хэлье Боромир: Дунаданчууд бид цөөхөн үлдсэн, бид байнга хэрэн хэсч явдаг. Яагаад гэвэл бид хилийн манаа адилаар өрнө, дорно хоёр газрыг заагласан Балар шугуйгаар доншуучилж, заримдаа бүр суурин газарт ч ороод ирдэг Дайсны гар хөл бологсдыг цуцалтгүй хайж байгаа юм.

Дайсны түрэлтийг тогтоон барьж, өрнө газрыг хамгаалж байгаа цорын ганц хүч бол бид гэж чи сая хэллээ. Гэтэл та нар хар морьтнуудтай эхэлж тулгарангуутаа Андуйн голын цаана шахагдан гарсан. Тэгэхлээр Боромир минь, ертөнц дээр Дайсны зохион байгуулалттай цэргээс гадна цохилт өгч байх ёстой олон хүч байдаг юм. Та нар хил хязгаараа хамгаалж, хөрш улсуудаа Моргулын армиас хаацалж байгаа. Та нар өөрийнхөө хил хязгаараас өөр юунд ч санаа зовоогүй, харин бид бол бүх харанхуй хар хүчинтэй тэмцдэг юм.

Хэрэв арнорчууд харанхуй хар хүчинтэй амрах чөлөөгүй тулалдан Балар шугуйн орноор хэсээгүйсэн бол дайсны цэрэг – нэргүй айдас умард болоод өрнөд газрын оршин суугчдыг аль хэдийн хөөгөөд явуулчих байсан юм. Хэрэв үзэгдэх биегүй нэргүй айдсууд баруун газарт саадгүй нэвтэрсэн бол бүр хамгийн алсын амгалан тайван газартаа ч гэсэн хэн өөрийн орон гэртээ тайван сууж чадах байсан бэ? Хэн тэдний эсрэг тулаанд зориглон хөдлөх байсан бэ?

Тэгвэл харанхуй шугуй, манант хавцал, ёроолгүй намгаас Мордорын хар холбоотнууд гарч ирэхэд арнорчууд тэднийг заавал угтан тулдаг, тэд Утаат уулын цаагуур ортлоо ухардаг юм.

Бид тэр ч байтугай талархлын үг ч шаардаагүй байна. Аян замд тааралдагсад бидэн рүү сэжигтэйгээ хялайж хардаг, Дундад газрын хот суурингийнхан болоод хөдөөгийнхөн биднийг өрөвдсөн ч юм шиг, биднээс жийрхсэн ч юм шигэ “тэнэмлүүд” гэж нэрлэдэг... саяхан хэн болохыг нь үнэнээр нь сонсох юм бол айсандаа үнхэлцэг нь хагарчихмаар амьтадтай хөрш амьдардаг нэг бүдүүн нөхөр намайг гомдоох гээгүй мөртөө “тэнэмэл” нэрлэсэн... бид яах гэж “тэнэж” явдгийг тэр мэдэхгүй болохоор намайг өрөвдөж л дээ хөөрхий. Гэвч бидэнд түүний талархал хэрэггүй. Тэр одоохондоо хөршүүдийнхээ адилаар амар тайван, өөрийнхөөрөө аз жаргалтай амьдарч байна. Энэ л бидэнд шагнал гэж бид боддог. Боддог байсан гэж хэлэх нь оновчтой байх...

Яагаад гэвэл ертөнц дахиад өөрчлөгдөж байна. Исилдурын хараалт бөгж урт удаан хугацааны дараа газар дороос гараад ирлээ. Бид агуу тулалдаанд орох боллоо. Хугарсан илдийг дахин давтана, тэгээд би чамтай Минас-Тирит явна.

- Исилдурын хараалт бөгж урт удаан хугацааны дараа газар дороос гараад ирлээ - гэж Боромир Арагорны үгийг давтаад - Би... нэг намхан нөхөр гялалзсан бөгж үзүүлэхийг харлаа. Та нар надад тайлбарлаад өгөөч, тэр бөгж мөн гэдэгт та нар яагаад ийм бат итгэлтэй байгаа юм бэ? Исилдур манай эрин эхлэхээс ч өмнө нас барсан, бөгж ор мөргүй алга болсон гээд байдаг, энэ олон он жилд тэр хаанаа байсан байж таарах вэ? Одоо энэ нөхрийн гарт яаж орсон байх вэ?

- Чи энэ тухай мэдэх болно оо – гэж Элронд амлав.

- Гэхдээ одоо биш биз дээ, эрхэм эзэнтэн? – гэж Бильбо сандарсан байртай хэлээд – Би үдийн зоогийн цаг болсон гэж бодож байна, би заавал тамир тэнхээ сэлбэх хэрэгтэй байна.

- Би одоохондоо чамаас юу ч гуйгаагүй байна гэж Элронд инээдээ барьж ядан хэлээд – Гэвч нэгэнт чи өөрийнхөө тухай өөрөө сануулсан болохоор, нэг юм гуйя. Өөрийнхөө намтрыг эдэнд ярьж өг. Хэрэв чи намтраараа найраглал биччихээгүй бол хүүрнэлээр ярьж өгөөрэй. Чи хэдийчинээ товчхон ярина, төдийчинээ хурдан тамир тэнхээгээ сэлбэнэ гэдгийг чамд тайлбарлах шаардлагагүй гэж бодож байна.

- За за, - гэж Бильбо зөвшөөрч: - Би өнөөдөр та нарт үнэн түүх ярьж өгье. Хэрэв зочдын хэн нэг нь гайхвал өнгөрсөн явдлыг ухаж тэнхэхгүй байхыг хичээнэ биз – гээд Бильбо Глоин руу нүдний булангаар харснаа - Сүүлийн жилүүдэд би олон зүйлийг ойлгож авлаа... Тиймээс намайг ч бас ойлгож, уучилна биз дээ! Үнэн явдал ийм юм...

Бильботой урьд нь уулзаж байгаагүй зочид түүний адал явдлын тухай ихэд гайхан сонсч, хөгшин хоббит бүх зүйлийг нэгд нэггүй санаж, Хорлумтай уулзсан тухайгаа ярьж чадсандаа баяртай байлаа. Тэр сүүлчийн оньсого хүртэл нэг ч үйл явдал алгасалгүй ярив. Тэр Хоббитаныг орхисон, их найр хийсэн, алга болсон, Удам хөндий хүртэл яаж ирснээ бүгдийг дуртайяа ярих байсан ч Элронд гараа өргөөд:

- Гайхалтай байна, найз минь. Чи нутгаасаа гарахдаа бөгжийг Фродод өгсөн тухай бид мэдэх нь чухал байна. Одоо чиний залгамжлагчийн яриаг сонсьё гэв.

Фродо бөгж хадгалагч болсноос хойш өөрт нь тохиолдсон бүх үйл явдлыг дэс дараалан ярих. Гэвч сонсогчид түүний яриаг дэндүү сонирхож, байн байн яриаг нь таслан лавлаж асуух нь яршигтай байв. Тэд түүний аян замын алхам бүрийг сонирхож, хар морьтнуудын төрх байдал ааш араншинг юу ч үлдээлгүй мэдэж авахыг хүсч байлаа. Эцэст нь яриагаа дуусгаад санаа амран суухад Бильбо:

- Муугүй шүү, найз минь, яриаг чинь байнга тасалж байсан нь харамсалтай. Би нэлээд юм тэмдэглэж авсан боловч заримыг нь амжсангүй. Хэрэв би номоо дуусгаж чадах юм бол чиний адал явдал хоёр гурван бүлэг болох юм байна – гэв.

- Тийм ээ, урт түүх болсон – Гэхдээ Гэндальф дэлгэрүүлж ярихгүй бол энэ түүх бүрэн болохгүй гэж би бодож байна – гэж Фродо хэлэв.

Хоббитуудаас холгүй сууж байсан Гэлдор Фродогийн энэ үгийг сонсоод:

- Намханы хэлдэг зөв шүү - гээд Элрондод хандаж, - Бөгжний тухай яриа бүрэн биш байна. Би ч гэсэн бага сага юм мэдэж авмаар байна. Та нар Боромирын асуултад хариулсангүй. Намханы авч яваа бөгжийг Мордорын Хар эзэн давтсан гэдгийг та нар яаж мэдсэн юм бэ? Саруман энэ тухай юу бодож байна вэ? Тэр Дайсныг сайн мэднэ, гэтэл тэр өнөөдөр яагаад ч юм энд алга байна. Хэрэв тэр бидний мэдэж байгааг мэдэж байгаа бол бидэнд юу гэж зөвлөх бол?

- Чиний асуултууд хоорондоо салшгүй холбоотой. Энэ холбоо бидэнд бас нэг түүхийг нээж өгнө. Тэр түүхийг Гэндальф ярьж өгнө. Энэ түүх бөгжний туужийг дуусгана. Учир нь Гэндальф бид бүхнээс илүүг мэднэ гэж Элронд хариулав.

- Гэлдор Зөвлөл дээр сонссон бүхнээ зүгээр нэг холбоогүй – гэж Гэндальф яриагаа эхлээд - Фродог хар морьтнууд хөөж байна. Даяныг шалгааж, Бильбогийн талаар мэдээлэл өгвөл шидэт бөгжнүүдийг буцааж өгнө гэж байна... Бильбогийн олз Мордорын эзэнд туйлын чухал гэдэг нь тодорхой биш байна гэж үү? Бильбо тэр бөгжийг олсон нь тодорхой болсон. Тэгвэл одоо бусад бөгжнүүдийн тухай бодоцгооё. Есөн бөгжийг хар морьтны дүрд хувилсан Дайсны дайчид зүүж явна, долоо нь алдагдсан юм уу, устгагдсан. /ингэж хэлэхэд Глоин давхийсэн боловч биеэ барьж дуугүй суув/ - Гурван бөгж хаана байгааг бид мэдэж байна. Тэгвэл Дайсан ямар бөгжний хойноос хөөцөлдөөд байна?

Боромирын зөв. Гол, агуй хоёрын хооронд – бөгж алдагдсан, олдсон хоёрын хооронд олон эриний харанхуй ангал байна, тэр ангалыг мэргэн ухаантнууд алгуур судалж байсан – хэтэрхий алгуур, хэтэрхий удаан. Мэргэд Дайсан ч мэргэн ухаантай гэдгийг мартсан. Дайсан зүгээр суугаагүй, тэгээд үнэнийг биднээс арай хожуу, аз болоход хожимдож өнгөрсөн зун л олсон. Тэглээ ч гэсэн мэргэд хариугүй хожимдох шахсан.

Манай эриний бүр эхэнд би Дул-Гулдур орж, хар шидтэн юу хийж байгааг тагнах эр зориг гаргасныг энд сууж байгаа хэн нэг нь мэдэж байгаа. Тэгээд би мөнхийн дайсан Саурон дахин

амь орж, хүчээ авч байгааг мэдсэн юм. Ингээд бидний болгоомжлол батлагдсан. Тэр үед болсон Зөвлөл дээр Саруман дайн эхэлж хэрэггүй гэж мэргэдийг ятгаж байсныг ч зарим нь санаж байгаа гэж бодож байна. Тэгээд л бид энэ олон жилийг зөвхөн ажиглаж өнгөрөөсөн. Гэвч Дул –Гулдурын дээгүүр хар үүл бүрхэж умар зүг рүү нүүхэд Саруман хүртэл дайтах хэрэгтэй гэж уриалан Мэргэдийн зөвлөлийн нөхөрлөл Хар эзнийг Балар шугуйгаас хөөсөн. Тэр жил бөгж олдсон, хэрэв энэ тохиолдол юм бол үнэхээр хачин тохиолдол.

Гэтэл мэргэд хэтэрхий алгуурлаж, үүнээс болоод бидний ялалт Уудам хөндийн эзний хэлсэнчлэн үр дүнгүй болсон. Саурон ч биднийг ажиглан тандаж нууц оромжоосоо есөн үл үзэгдэгч зарцаараа Моргулийн цайзыг эзлүүлэн, манай довтолгоог няцаахаар бэлтгэсэн. Манай цэрэг Балар шугуйд дөхөж очиход тэр дайтах гэж байгаа дүр үзүүлсэн мөртөө өөрөө өмнө зүг рүү нэн даруй ухарч, Мордорын хилийн харуул, Хар цайзын харуул хамгаалалтыг устгаад, өөрийгөө тэндхийн эзэн гэж ил тод зарласан. Тэр бат бэх цайзад бэхэлсэн болохоор бидний яаран цуглуулсан нөхөрлөлийн армид дийлдэхгүй нь мэдээж учир бид Зөвлөлийг дахин хуралдуулсан. Тэр бөгжийг хайж байгаа гэдгийг бид ойлгосон учраас тэр. Дайсан энэ шургуу эрлээрээ ямар нэг юм олж мэдэж чадсан уу гэдгийг бид тэр хуралдаанаараа хэлэлцсэн юм. Гэвч Саруман урьдын л адилаар бүгдийн захирагч бөгж хэзээ ч олдохооргүй ор мөргүй алга болсон гэж мэргэдийг тайвшруулсан билээ.

“Бид одоо болтол тэр бөгжийг эрж хайхгүй байгааг Дайсан мэдэж байгаа. Тиймээс тэр бөгж хайж олох гэж цагаа алдана. Тэрний найдвар хэзээ ч биелэх тавилангүй. Бөгжийг их Андуйн мөрөн залгисан Сауруныг хий үзэгдэл байх хойгуур мөрний урсгал тэрний эрдэнийг тэнгист үйсэн, тэнгисийн гүнээс бөгж байтугай юу ч эргэж ирдэггүй. Бүгдийг захирагч бөгж үүрд амар жимэр болсон” гэж Саруман хэлсэн юм.

Гэндальф дуугүй болж, бэлээр нь бүгдийг захирагч бөгжийг удаан хугацаагаар хадгалсан мөрөн урсч байгаа Манант уулсыг цонхоор ширтэв.

- Би маш их буруутай, Саруманы үг намайг тайвшруулж, би энэ аюулыг хэтэрхий оройтсон хойно мэдсэн – гэж Гэндальф хэлэв.

- Бид бүгдээрээ буруутай – гэж Элронд хэлээд – ганцхан чиний ачаар л Дундад газрыг бүхэлд нь харанхуй хар хөшиг нөмрөөгүй ч байж магадгүй – гэв.

- Саруманы баталгаа нотолгоо намайг тайвшруулсан боловч би сэтгэлийн гүндээ аюулыг мэдэрч байсан – гэж Гэндальф хүндээр санаа алдан яриагаа үргэлжлүүлэв:

- Тийм учраас золгүй муу Хорлумд тэр бөгж хэзээ, яаж орсныг мэдэх гэж тун их хүсч байлаа. Тэр “эрдэнэ”-ээ хайж олохын тулд газар дорх ичээнээсээ мөлхөж гарах ёстой байсан, тиймээс би тэрнийг мөрдөхөөр шийдсэн юм. Тэр мөлхөж гарсан боловч мөрдөгчдөөс чадмаг нуугдаж, дахин газар доогуур орсон юм шиг алга болсон. Тэгэхэд нь би Дайсныг тайвнаар тандан юу ч хийхгүй зүгээр сууж байснаа хэзээ ч уучлахгүй.

Цаг хугацаа шинэ шинэ асуудал төрүүлсээр миний хуучин айдас аажмаар бүдгэрсэн юм.... гэвч нэг удаа тэр айдас санаандгүй сэргэж, гүнзгий түгшүүр болж хувирсан. Хорлумаас Бильбогийн булааж авсан тэр бөгжний жинхэнэ эзэн хэн бэ? Хэрэв миний таамаг нотлогдвол

би яах ёстой вэ? Миний шийдэх ёстой асуудал энэ байлаа. Энэ тухай би хэнтэй ч яриагүй. Учир нь болгоомжгүй хэлсэн үгийг хэн ч сонсч болно. Бид Дайсантай тоолшгүй олон удаа тулалдахад чалчаа үг ямагт гай зовлон болон эргэж байсан учраас бид урвагчаас айдаг болсон билээ.

Бильбогийн бөгжийг би арван долоон жилийн өмнөөс сонирхсон. Тэр үед Хоббитаны эргэн тойронд тагнуул туршуулууд шиншилж байгааг би маш түргэн илрүүлсэн. Хар эзэнд зарим араатан, шувуу хүртэл үйлчилж байсан юм. Би дунаданчуудаас тусламж гуйхад тэд олон тагнуул туршуулыг устгасан. Дараа нь Арагорнд нууцаа дэлгэхэд тэр намайг дагуулж Хорлумыг олохоор Бөглүүд газар руу одсон юм.

- Хорлумыг заавал олох хэрэгтэй гэж би Гэндальфт итгүүлсэн – гэж Арагорн үг хавчуулаад – Хорлумыг олох цаг одоо байхгүй гэж тэр бодож байсан юм. Гэвч би Исилдурын удам угсаа, залгамжлагчийн хувьд түүний алдааны төлөө өөрийгөө золиослохыг хүсч байсан тул Гэндальфтай хамт эрэлд мордсон юм.

Гэндальф Арагорнтой хэрхэн аялж, Дайсны эзэмшлийн газрын хязгаар Тортогт уул хүрч, тэнд Хорлумын тухай мэдээ анх сонссоноо Зөвлөлд товчхон ярив.

- Бид хоёр тэрнийг уулын хаа нэгтээ нуугдаж байгаа гэж бодоод бараг хавцал, агуй бүрийг самнасан боловч олж чадаагүй. Тэгээд би эрэлдээ цөхөрч, буцахаар шийдсэн юм. Гэтэл миний ой дуртгалыг гагцхүү тэр цөхрөл л сэргээж, Зөвлөлийн хуралдаан дээр хагас дутуу сонссон Саруманы үгийг санасан юм.

“Шидэт бөгжнүүд бие биеэсээ эрдэнийн чулуугаар ялгардаг юм. Бүгдийг захирагч бөгжийг Саурон төгс гилгэр давтсан боловч дээр нь нууц бичээс байгаа, түүнийг Мэргэн уншиж чадна” гэж Саруман хэлсэн юм.

Саруман өөр юм хэлээгүй. Би энэ үгийг санаад нууц бичээсийг яаж тодруулдгийг хэн мэдэх ёстой вэ гэж бодсон юм. Мэдээж, түүнийг бичсэн хүн мэдэж таарна. Саурон. Саруман яах бол? Тэр хичнээн гарамгай мэргэн ч гэсэн тэр бөгжийг нэг ч удаа хараагүй болохоор нууц бичгийг тайлж чадахгүй, тэгэхлээр тэр нууцыг хэн нэгнээс мэдсэн байж таарна. Бөгж алга болохоос өмнө Хар эзнээс өөр хэн тэр бөгжийг харсан билээ? Ердөө ганцхан хүн - Исилдур. Би Хорлумыг олох найдвар тасарч хайхаа ч больж, Гондор руу явлаа. Нэгэн цагт тэнд мэргэдийн номыг уншдаг байсан, Саруманд онцгой хүндтэй ханддаг байсан, тэр ч их вангийн удаан хугацаагаар байсан. Дээд захирагч Денэтор намайг урьдынхаасаа нэлээд болгоомжтой хүлээн авч, эртний гар бичмэлүүд болон номын санд тун ч дургүй оруулсан юм.

“Гондорын эртний сурвалж бичгүүдийг сонирхож байгаа чинь үнэн юм бол яая гэхэв, уншуулахаас” – гэж тэр надад дуртай дургүй хэлээд – “харин миний хувьд өнгөрсөн цаг ирээдүйгээс тод байдаг юм..., гэхдээ энэ бол миний хэрэг. Гэвч хэтэрхий мэргэн Саруман хүртэл эндээс миний мэддэг зүйлийг л олсон “ гэлээ.

Денэтор надад тэгж тус болсон юм. Ямар ч гэсэн би тэр санд бараг хэн ч үл ойлгох гар бичмэлүүдийг олсон. Учир нь балар эртний ард түмнүүдийн бичгүүдийг зөвхөн мэргэдийн

мэргэд л мэддэг юм. Тийм ээ, Боромир, Исилдурын өөрийнх нь гар бичмэлийг эрж олсон юм. Тэр бичгийг надаас өөр хэн нэгэн уншаагүй, харин Саруман уншсан байж болох юм. Дайсныг ялсныхаа дараа Исилдур умардын домогт өгүүлсэнчлэн ”хаа нэгтэй алдар хүндгүй үхэхээр явсан” биш, Гондорын вант улсад ирсэн байна.

- Умардынхан тэгж хэлсэн байж магадгүй юм, харин гондорчууд бид Исилдур дайнд амь үрэгдсэн ахынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэн түүний хүү Менельдилд вант улсаа хүлээлгэж өгөхөөр Гондорт үнэхээр эргэж ирсэн гэдгийг аль эртнээс мэддэг байсан, тэр манай улсын нийслэлд Цагаан модны сүүлчийн үрийг суулгасан юм.

- Тэгэхдээ сүүлчийн бичгээ бичсэн байна гэж Гэндальф Боромирын хэлснийг гүйцээгээд - харин энэ тухай Гондорынхон мартсан бололтой. Энэ бичээс Исилдур Сауронтой тулалдаж байхдаа олсон бүгдийг захирагч бөгжний тухай байлаа. Би тэр бичгийг тайлан уншиж чадсан. Ингэж бичсэн байлаа:

“Одооноос эхлэн бүгдийг захирагч бөгж Арнорын эзэнт улсын их вангуудын өмч болно. Гэхдээ би бөгжийг Гондорт үлдээлээ, учир нь энд ч гэсэн Элендилийн удам угсаа амьдарч байгаа, тиймээс ч манай эриний гайхамшигт үйл явдлууд өмнөдөд мартагдаагүй “ гэсэн байлаа.

Тэгээд бөгжний тухай ингэж бичсэн байв:

“Бөгжийг би барьж үзэхэд дөнгөж сая Галт уулын тогооноос гаргаж авсан юм шиг улайссан байв. Миний гарын түлэнхий хэзээ ч эдгэрэхгүй юм шиг надад санагдаж байлаа. Гэвч эдгэрсэн, бөгж ч хөрч, арай жижигхэн болсон мэт харагдаж байсан, гэхдээ Дайсны урласан өнгө зүс, хэлбэр дүрс, нүд булаасан үзэмж нь хэвээр үлдсэн. Харин түүн дээрх шидэт тэмдгүүд бүдгэрсээр бараг алга болсон. Үсэг нь Остранны эльфүүдийн тэмдэг үсэг мөн боловч бичгийн утга ойлгомжгүй байлаа. Хэл нь Дайсны хэл бололтой үсэгнүүдийг уншихад нэг л муухай, нууцлаг авиа гарч байв. Дайсны энэ бичиг ямар аймшигт аюул агуулж байгааг би мэдэхгүй, тиймээс дөнгөж үзэгдэх төдий байгаа бичээс оргүй алга болж магадгүй тул үр удмынхаа ой тойнд үлдээхийн тулд би түүнийг хуулж бичлээ. Бүгдийг захирагч бөгжинд Дайсны алганы халуун дутагдаж байгаа юм шиг санагдаж байна. Яагаад гэвэл тэр улайссан байхдаа хар хүрэн, бүр шөнийн харанхуй мэт хар байсан, Гил-Гэлад амь үрэгдсэн байсан, хэрэв бөгжийг галд хийвэл нууцат бичээс тодрох байх, гэвч би энэ бөгжинд хор хүргэхээс эмээж байна, яагаад гэвэл энэ бөгжний төлөө нуменорчууд хэтэрхий их үнэ төлсөн болохоор бөгж миний хувьд маш их үнэтэй юм шиг санагдаад байна”.

Миний таамаг ингээд батлагдлаа. Дайсан эльфүүдийн үсгийг ашигласан боловч мордор хэлээр бичжээ. Энэ бичиг эртнээс мэдэгдэж байсан, учир нь Дайсан бөгжийг давтаж байхад эльф Селебримбер Сауроны шидэт үгсийг тод сонсч түүний утгыг ойлгосон байдаг. Саурон бүгдийг захирагч бөгжин дээр бичиг цохиж байхдаа үглэн давтаж байжээ.

Би Денэтортой салах ёс гүйцэтгээд Хоббитан руу яарлаа. Гэвч замдаа эльфүүдтэй уулзахад Арагорн яаж ийгээд Хорлумыг барьсан тухай сонсов. Ингээд би эхлээд Бөглүүд ой руу явав. Арагорн Мордорын хил орчимд Хорлумыг мөрдөж явахдаа үхлийн аюул давсан байв. Энэ тухай тэр өөрөө яриг.

-Яриад байх ч юу байхав дээ. Хар цайзын хажуугаар нэвтрэх юм уу, үхлийн цэцэгс нь цэцэглэж байгаа Моргулийн хөндийгөөр гарахад аюулыг даван туулахаас өөр аргагүй. Би Хорлумыг олж чадсан, эрж цөхрөөд умар зүг рүү эргэтэл эрж явсан юмаа гэнэт олдог юм байна. Нэг жижиг нууранцрын эргийн элсэн дээр нүцгэн хөлийн мөр олдлоо, тэр мөр өмнө зүг рүү биш, умар зүг рүү, Мордор руу чиглэсэн байв. Хорлум Үхмэл намгийн дэргэдүүр явсан байлаа. Хоёр хоногийн дараа би тэрнийг барьсан. Тэрний бүх бие нь намгийн замаг шиг ногоон болсон байсан. Тэр намайг эсэргүүцэх гэж оролдсон, би ч тэрэнтэй ёсорхоогүй, дараа нь тэр миний асуултад хариулах нь байтугай зөвхөн идэх гэж л амаа ангайж байсан. Би өөрөөсөө гадна тэрэнд идэх юм олж өгч явлаа. Барьсан олзтойгоо умар зүг явах нь надад түүнийг хайж явахаас хавьгүй бэрх байлаа. Замын туршид би тэрний аманд шуудайны өөдөс чихээд, хүзүүнээс нь олсоор оосорлон тууж явсан. Арай гэж Бөглүүд ой хүрээд Трандуилын эльфүүдэд тэрнийг тушаах үед миний хөл гуйвж, салхинд өвс шиг найгаж байсан. Би тэрэнтэй дахиад уулзахгүй гэж найдаж байна. Тэр үй олон муухай юмнаасаа гадна бас хамартай амьтан ойртохооргүй өмхий байсан. Гэвч Гэндальфын хамар тэрнийг нь тоогоогүй, хангалттай удаан хууч хөөрнө лээ.

- Удаан, гэхдээ үр ашигтай яриа байсан – гэж Гэндальф Арагорны шоглож хэлсэн үгийг үл анзаарагч болон өгүүлээд – Нэгдүгээрт, Хорлумын ярьсан зүйл сая Бильбогийн ярьсантай зөрөхгүй байлаа. Гэвч энэ тийм ч чухал биш байсан. Би өөрөө тэр тухай таамаглаж байсан. Юу чухал байсан бэ гэвэл, Хорлум бөгжийг энэ эриний эхээр Ирисийн хонхор дахь Их мөрний эрэг дээрээс олсон гэж ярьсан юм. Тэр үхэлт амьтан учир аль эрт үхэх байсан, гэтэл хангалттай удаан амьдарсан байна, тэгэхээр тэрний амьдралыг бөгж уртасгаж байжээ. Зөвхөн бүгдийг захирагч бөгж л эзнийхээ амьдралыг уртасгадаг, бусад бөгж ингэж чадахгүй гэдэг нь тодорхой.

- Хэрэв энэ баримт чамайг итгүүлж чадахгүй байгаа бол өөр нэг баримт байна – гэж шидтэн Гэлдорт хандаж хэлээд - Та нар бүгдээр намхан эрийн барьж байгаа бөгжийг харлаа. Алтан, дугариг, ямар нэг чимэггүй. Гэвч түүнийг галд баривал Дайсны хараалын үг тодорно. Ингэх зоригтой хүн цөөхөн байх л даа. Нэг удаа би энэ бөгжийг гал руу хийгээд ийм бичээс байгааг уншсан:

Эш назг дурбатулук, эш назг гимбатул, эш назг тхратулул, агх выфзым-иши кримпатул!

Шидтэний дуу хоолой гэнэт заналхийлсэн шинжтэй болж, үг нь бөглүү бөгөөд жигдхэн мөртөө хүчтэй нүргэлэхэд Шилтгээний бат бэх хана доргиж, хурц нар бүдэгрэн утаанд бүрхэгдээд явчихав...

- Энэ хэл Имладрист хэзээ ч сонсогдож байгаагүй - гэж Элронд танхимд чимээгүй болж, Зөвлөгөөнд оролцогчид сая амьсгаа авсны дараа хэлэв.

- Дахиад хэзээ ч сонсогдохгүй гэдэгт найдаж байна - гэж Гэндальф Уудам хөндийн орны эзэнд хариулаад – Гэхдээ надаас - Саарал Гэдальфаас баталгаа нотолгоо шаардсан учир би чамаас уучлал гуйхгүй. Энэ хэлний авиа баруун газрыг нэгмөсөн үгүй болгохгүйн тулд энэ намхан эрийн барьж байгаа бөгж бол эрт цагт мэргэдийн таньсан Дайсны далд хүчний эрдэнэ мөн байна гэдэгт үнэмших хэрэгтэй. Хар жилүүдийн харанхуйд Остранны эльфүүд ийм хараалын шидийн үгсийг анх сонссон юм:

Харанхуйд ууссан Мордор нэртэй оронд

Хар эзэн нэг бөгжийг зүүнэ.

Нэг бөгж бусад бөгжийг цуглуулж захирна

Нэг бөгж тэднийг хар гинжинд хэлхэж давтана.

Үүнийг сонсоод эльфүүд урвалтын торонд орсноо ойлгосон юм.

Хорлум ярих их дургүй, ойлгомжгүй ярьсан ч би олон зүйлийг мэдэж авсан. Тэр Мордорт нэвгэрч чадсан, тэнд Дайсны зарц нар түүнийг барьсан, тэгээд эрүүдэн байцааж бүх зүйлийг хэлүүлж авсан байна. Тиймээс Дайсан энэ бөгжийг олдсон, Хоббитанд удаан хугацаагаар байсан, одоо өөр тийшээ алга болсныг мэдэж байгаа юм. Магадгүй хоббитууд бөгжийг эльфүүдэд авчирч өгсөнийг ч мэдэж байгаа. Есөн үл үзэгдэгч зарц нь Фродог Уудам хөндий хүртэл мөрдөн хөөсөн шүү дээ...

- ...Тэр Хорлум гэдэг чинь нэг жижигхэн муухай амьтан уу? Жижигхэн муухай амьтан мөртөө их эд байх нь ээ? Тэрнийг яаж шийтгэсэн бэ? – гэж Боромир танхимын эвгүй нам гүмийг эвдэв.

- Тэрнийг Умард бөглүүд ойд хорьсон, тэгээд л болоо. Тэр их зовлон эдэлсэн. Дайсны оронд тэрнийг тамласан юм шиг байна лээ. Тэрний айдас одоо ч арилаагүй байгаа. Тэрнийг Бөглүүд ойн сонор сэрэмжит эльфүүд хамгаалж байгаад би баяртай байна. Цөхрөл, үзэн ядалт, зовлон, айдас нийлээд түүнийг маш аюултай болгосон, хэрэв тэр чөлөөтэй байсан бол тэр муухай амьтан ямар ч гай тарьсан би гайхахгүй. Тэрнийг Дайсны хар санаат төлөвлөгөөгүйгээр Мордороос тавихгүй л байсан байх. Харахад хариугүй амьтан боловч үзэн ядалт түүнийг асар их хүтэй болгосон!

- Намайг муу мэдээтэй илгээсэн – гэж эльф Леголас гэв гэнэтхэн чанга хэлээд – тэр мэдээний жинхэнэ аймшигт утгыг би сая л ойлголоо. Учир нь Хорлум гэж нэрлээд байгаа Смеагорл харгалзагч нарыг хөнөөгөөд хаа нэгтээ алга болсон-гэв.

- Алга болсо-он? – гэж Арагорн хашгирах шахам асуугаад – Энэ чинь ёстой зэвүүн муухай мэдээ байна шүү. Эльф харгалзагч нар яахаараа гэнэ алддаг байна?

- Бидний өрөвч сэтгэлийг ашиглаж оргосон. Гэхдээ тэрэнд гаднаас тусалсан нь илт байгаа юм. Энэ бол бидний ажил хэргийг Бөглүүд ойн цаана хэн нэгэн мэдэж байгаа гэсэн үг. Бид харгалзагч хийх хэзээнээс дургүй боловч тэрнийг сайн дураараа харгалзаж байсан юм. Гэндальф тэндээс явахдаа хоригдлын хар цөхрөлийг гүнзгийрүүлэх хэрэггүй гэж Трандуилд хэлсэн юм. Тэгээд бид тэрнийг үргэлж газар доор байлгаад яахав гэж шийдээд салхинд гаргаж зугаалуулдаг байсан юм... гэж Леголас хэлэв.

- Та нар надад хамаагүй илүү хатуу ханддаг байсан даа – гэж Глоин түүний үгийг нүд нь гялалзан таслав. Тэр эльфүүдэд хоригдож байснаа санажээ. Түүнийг цаг үргэлж газар дор хорьж байсан ажээ.

- Тайвшир найз минь, өнгөрсөн үеийн арилгасан зөрчлийг дурсаад яахав. Хэрэв эльфүүд, гномууд хуучин гомдлоо уудлаад байвал зөвлөл хэзээ ч дуусахгүй – гэж Гэндальф өгүүлэв.

Глоин босч дуугүй мэхийгээд суухад эльф тасарсан яриагаа үргэлжлүүлэв.

- Цаг агаар сайхан өдөр бид тэрнийг ойн цоорхойд гаргаж салхилуулдаг байсан юм, ойн цоорхойн дунд аварга том ганц мод байдаг, хоригдол тэр модонд бүр дээр авирч гараад навчнууд дунд нуугдан удаан суудаг харгалзагчид доор нь хүлээж суудаг байсан. Гэтэл тэр нэг удаа бууж ирэхээс татгалзсан юм. Харгалзагчид тэрнийг хүчээр буулгахаас түдгэлзэж хүлээсэн. Тэр ер нь дөрвөн мөчөөрөө модны мөчрөөс үхэн хатан зууралдахаараа салдаггүй учир харгалзагчид жаахан төвөгшөөсөн юм байх. Тэртэй тэргүй зугтаах газар байхгүй юм чинь.

Яг тэр үдэш бидэн рүү орхууд гэнэт довтолсон. Ширүүн тулалдаан болж, үүрээр бид ялж, үлдсэн орхууд зугтаасан. Дэндүү олон орх дайрсан, галзуу мэт улайран тулалдаж байсан боловч Уулын чанадах тал газрын амьтад болохоор ойд тулалдаж сураагүй байсан тул бид дийлсэн... Дайсныг үлдэн хөөчихөөд Хорлумыг санаж хайтал харгалзагчид нь алагдаж, өөрөө хаа нэг тийш алга болсон байлаа.

Тэрнийг хулгайлахын тулд довтолсон, тэгэхдээ тэрэнд энэ талаар урьдчилсан мэдэгдсэн шиг байгаа юм, харин яаж мэдэгдсэнийг бид хараахан мэдэхгүй байна. Хорлум тун зальтай новш, дайсны тагнуул туршуулууд улам олширч байгаа. Нумчин Бард Лууг устгахад бид хар хүчнийг Бөглүүд ойгоос хөөж гаргасан боловч тэд одоо дахиад үзэгдэх болсон, манай суурин одоо эргэн тойрноосоо дайсанд бүслэгдсэн арал болоод байна. Оргодлын мөрийг бид дараа нь олсон, тэр өмнө зүг рүү чиглэсэн байсан, гэхдээ тэрний мөрийг орхуудын мөр балласан байна лээ. Бид мөрийг мөшгөсөөр Бөглүүд ойн хамгийн аюултай газар Дул-Гулдур руу орсон учир бид цааш мөрдөх боломжгүй болсон. Бид тийшээ зүглэхээс айдаг юм...

- Товчхондоо тэр алга болсон, одоо бид тэрнийг хөөж явах цаг байхгүй. Тэрний заяа ийм юм байлгүй. Тэр өөрөө ч, Мордорын эзэн ч тэрнийг ямар ирээдүй хүлээж байгааг мэдэхгүй байж болох юм – гэж Гэндальф хэлэв.

Тэр хэсэг дуугүй сууснаа:

- Одоо би Гэлдорын асуултад хариулъя. Яагаад бидний дунд Саруман байхгүй байна? Тэр бидэнд ямар зөвлөгөө өгч чадах байсан бэ? Энэ бол ярихад нэлээд урт түүх, энэ тухай одоохондоо ганцхан Элронд мэдэж байгаа. Би энэ түүхийг түүнд товчхон ярьсан, яагаад гэвэл Дундад газрын өмнөх гай зовлон дээр дахиад нэг ноцтой аюул нэмэгдсэн. Бөгжний тухай өнөөдрийн яриа энэ түүхээр дуусна.

Энэ зун намайг Хоббитанд байхад миний сэтгэл нэг л жигтэйхэн байнгын түгшүүртэй байлаа. Тэгээд би тэр амгалан тайван жижиг орны өмнөд хил рүү явсан юм. Аюул маш хурдан ойртож байгааг би мэдрээд байсан боловч чухам ямар аюул вэ гэдгийг мэдэхгүй байсан юм. Өмнөд хил дээр очоод би Гондорт дайн болж байгаа тухай, гондорчууд мөрний наад талд ухарч гарсан тухай мэдэж авлаа. Хар морьтнуудын тухай сонсоод би ойртож байгаа аюулыг улам хурц мэдэрсэн. Гэтэл хар морьтнуудыг хэн ч үзээгүй юм шиг байдаг, өмнөдөөс

дүрвэж яваад надтай зам дээр тааралдсан дүрвэгчид маш их айсан байсан, тэгсэн мөртөө чухам юунаас айснаа нуугаад хэлэхгүй байсан. Тэгэхээр нь би Далд зам руу эргэсэн юм. Уулын суурингийн ойролцоо би Радагаст Карийтай тааралдлаа. Тэр бас миний адил мэргэн алдартай юм. Радагаст нэгэн цагт Бөглүүд ойтой зэргэлдээх Сарнайн хязгаарт амьдардаг байснаа хаа нэг тийш нүүгээд явчихсан байсан юм л даа... тэгсэн чинь мань эр замын хажуугийн далан дээр сууж байх юм. Морь нь дэргэд нь идээшилж байна.

“Гэндалф! – гэж Радагаст баяртайяа хашгирч - Би чамайг л хайж яваа юм шүү дээ. Чамайг баруун газарт Хоббитан хэмээх болхи нэртэй оронд амьдарч байгаа гэж надад хэлсэн. Би тийм нэртэй газар мэдэхгүй” гэлээ.

“Зөв л хэлсэн байна. Эндээс Хоббитан хүрэхэд дэндүү ойрхон. Харин болхи нэрний тухайд бол чимээгүй байсан нь дээр. Хоббитанчууд их гомдомтгой ардууд шүү. Харин чи их чухал мэдээтэй яваа юм шиг байна. Чи ер нь аян замд гарах хэзээний дургүй шүү дээ, арай аянчин болчихсон юм биш биз дээ?”

“Маш чухал” – гэж Радагаст хэлэв. Тэгснээ эргэн тойрноо сэрэмжлэн хараад:

- Маш чухал, маш муу мэдээ байна. Дайсны зарц нар. Тэд дахиад гараад ирлээ. Энэ удаа хар морьтны дүрээр. Тэд Мөрнийг гаталж дөнгөсөн байна, одоо баруун хойт зүг рүү хөдөлцгөөж байна гэж тэр хэллээ.

- Ийм учраас л миний сэтгэл түгшээд байсан юм даа – гэж Гэндалф Фродо руу харангаа хэлэв..

“Дайсанд ямар нэг нууц хэрэгцээ байна, эсвэл ямар нэг нууц төлөвлөгөө байна даа “ – гэж Радагаст надад хэллээ.

“Чи юун тухай яриад байна?” - гэхэд .

“Үл үзэгдэгч морьгнуудад Хоббитан ямар хэрэгтэй юм бэ?”- гэв.

Тэгэхэд миний дотор эвгүй болох шиг болсон. Учир нь үзэгдэх биегүй есөн зарцтай тулалдахаас хамгийн баатарлаг мэргэн ч айна, яагаад гэвэл тэд урьд нь цөм агуу баатар дайчид байсан, тэдний удирдагч Хар шидэт хаан хий үзэгдэл болоогүй, үзэгдэх биетэй байхдаа ч бүх дайсныхаа зүрхийг чичрүүлж байсан юм.

“Хэн чамайг над руу явуулсан юм бэ?” – гэж намайг асуухад:

“Цагаан Саруман – гэж Радагаст хариулаад – Хэрэв чамд ямар нэг тусламж хэрэгтэй бол Ортханк руу яв, харин хурдлаарай”.

Энэ үг намайг баярлууллаа. Саруман бол Мэргэдээс мэргэн... гэж би боддог байсан юм. Радагаст ч гэсэн бас л хүчирхэг шидтэн, ургамал, амьтны жинхэнэ эзэн хаан (ялангуяа шувууд түүнд онцгой үнэнчээр үйлчилдэг юм), Саруман бүр эртнээс Дайсныг тандаж, түүний бүх дадал зуршил, зан араншинг судалсан болохоор надад байн байн тусалдаг байсан юм. Бид

Саруманы мэргэн зөвлөгөөний ачаар дайсныг Дул-Гулдураас амархан хөөж гаргасан, тийм учраас өмнөд нутагт дайсан хариу ялалт хийсэн нь намайг гайхуулахгүй байна...

“Би Саруман руу явна” – гэж би шууд хэлсэн. Хар морьтнуудыг Андуинаас яаж хөөхийг Саруман мэдэж байгаа байх гэж би бодсон юм л даа.

“Тэгвэл яг одоо хөдөл – гэж Радагаст намайг яаруулж – би чамайг хангалттай удаан хайлаа, Саруман хар морьтнууд намрын эхэн сард Хоббитанд хүрнэ, тэр цагт би чамд тус болж чадахгүй гэж хэлүүлсэн. Харин би одоохон явалгүй болохгүй” гээд Радагаст морио дуугаралгүй дуудаж, үсрэн мордоод ухасхийхэд нь би:

“Хүлээж бай, Радагаст! - чи өөрийнхөө цэргүүд – араатан, жигүүртнүүдэд бидэнд тусал гэж тушаал дамжуулаарай “ гэж түүний араас хашгирлаа.

“Тэдэнд тушаал өгсөн гэж мэд” – гэж тэр хашгираад есөн хар морьтоос зугтааж байгаа юм шиг нүдэнд үзэгдэхгүй нисэн алга болов.

Би түүний араас явж чадаагүй. Миний морь олон хоног тасралтгүй давхисаар ядарсан, би ч өөрөө амрахын хүслэн болж байсан, тэр өдөр бид хоёр асар их орон зай туулсан, гол нь би бодол санаагаа цэгцлэх шаардлагатай байсан учир маргааш өглөө хөдөлбө гэж шийдсэн юм. Энэ алдаагаа би хэзээ ч уучлахгүй!

Фродод би дэлгэрэнгүй захидал бичээд, эльфүүдийн оронд уулзахаар товлож, тэр тухайгаа тайлбарлаад миний эртний танил, мухлагийн эзэн Лавр Наркисст захидлаа найдвартай хүнээр хүргүүлэхийг даалгаж, хар үүрээр замдаа гарсан. Саруман бас өмнө зүгт, гондорчуудын Мустангрим гэж нэрлэдэг Ристанаас хойгуур, Изенгардын цайзад суудаг юм. Ристанийн тэгш талыг өмнө талаас нь Гондорын Цагаан нуруу хойт талаас нь Манант нуруу хаадаг бөгөөд хоёр талаас нь нэвтэршгүй шахам өндөр уулсын хөндийд эгц хадан хясаагаар хүрээлэгдсэн Ортханк шилтгээн байдаг. Нууц хаалгануудтай, их өндөр тэр шилтгээнийг эрт цагт нуменорчууд босгосон бөгөөд түүнд хадан хавцлуудын хаалга болох Изенгардын хавцлын цаадах хаалгаар л нэвтэрч болно.

Орой болохын хирд би хаалганд хүрч очиход үй олон хамгаалагч байсан бөгөөд Саруман аль эрт намайг хүлээж байсан бололтой, хаалга цэлийтэл нээгдэхэд би орсон, орсны дараа хаалга ард чимээгүй хаагдахад нь яагаад ч юм би гэнэт их л сэрэмжилж эхэлсэн.

Нэгэнт орсон юм чинь би шилтгээнд явж хүрэхэд Саруман шатаар яаралгүй бууж ирээд намайг дээд талын нэг өргөөндөө оруулсан. Түүний хуруунд бөгж байгааг би анзаарлаа.

“Ингээд чи хүрээд ирлээ” – гэж тэр тайван хэлсэн боловч нүдэнд нь хүйтэн тохуу гялалзахыг би бас анзаарав.

“Хүрээд ирснийг харж байгаа биз дээ, надад чиний тусламж хэрэгтэй байна, Цагаан Саруман!” – гэж би хариуллаа. “Цагаан” – гэж хэлүүт Саруманы уур дүрсхийгээд явчихав.

“Чи надаас тусламж гуйж байна уу, Саарал Гэндалф? – гэж тэр илэрхий тохуурхсан өнгөөр

асуугаад – Тэгэхлээр Дундад газрын ажил хэрэгт гурав дахь эриндээ оролцож байгаа хэтэрхий ухаантай, хаана л бол хаана явж байдаг шидтэнд урьдын адил гуйхгүйгээр, урилгагүйгээр тусламж авах хэрэг болоо юу?” – гэж асуулаа.

Түүний дууны өнгө ер бусын хорон байгаад би гайхав.

“Радагаст Каремыг над руу элч заран илгээж бид хүчээ нэгтгэх хэрэгтэй байна гэж хэлсэн шидтэн чи биш гэж үү?”

“Би түүнд тэгж хэлсэн гэж бодъё. Харин одоо чи ямар учраас ийм орой наашаа ирснээ хэлээд аль. Чи мэргэдийн Зөвлөлөөс болон надаас, үнэхээр агуу чухал Мэргэдийн дээд зөвлөлөөс ч удаан нуугдлаа! Харин одоо болохоор Хоббитан дахь хоргодох байраа орхиод над руу яаран ирээ шив...яах гэж?”

“Яагаад гэвэл есөн бөгжтөн үл үзэгдэгч амьдралаа дахиад эхэлжээ. Тэд Мөрнийг гаталсан гэж Радагаст хэлсэн...”

“Радагаст Карий юу? – гэж Саруман тачигнатал хөхрөн миний яриаг таслаад - Радагаст – Догшин захирагч Бялзуухай юу? Радагаст Маанаг! Радагаст Тэнэг! Эргэцүүлж бодолгүйгээр тэнэг үүргээ гүйцэтгэх ухаан хүрсэн нь сайн хэрэг! Тэр үүргээ муугүй гүйцэтгэлээ – тэгээд л чи энд байж байна. Чи эндээ үлдэх болно, Саарал Гэндальф, - Чи аян замын ядаргаагаар тайлж амрах хэрэгтэй. Яагаад гэвэл Бөгжнүүдийн гүрний захирагч Саруман би ингэж хүсч байгаа юм!” – гэж тэр хэлэхэд үзэн ядалт уур хилэн нь ил тодроод ирлээ.

Тэр огцом ухасхийн босоход цагаан өмсгөл нь олон өнгөөр солонгорон нүд эрээлжлүүлэв.

“Цагаан өмсгөлтөн болох амаргүй. Өөрийгөө дахиад цайруулах бүр ч хэцүү” гэж би хэллээ.

“Цайруулахий? Яах гэж? – хэмээн Саруман мушилзаад – Цагаан өнгө мэргэдэд зөвхөн эхэн үед л хэрэгтэй. Цайруулсан юм уу, цагаан өнгийн даавууг өөр өнгөтэй болгоход амархан, цагаан цаасан дээр ямар ч мэргэн ухааныг буулгахад хялбар”.

“Цагаан өнгөө алдчихаар л амархан хувирч байгаа нь тэр, мэргэн өөрийнхөө өнгөнд үнэнч байгаа цагтаа л мэргэн” – гэж намайг зөрөхөд:

“Боллоо! – гэж Саруман миний үгийг шууд таслаад – надад чиний сургаалыг сонсох зав алга. Чамаар би эцсийн шийдвэрийг чинь гаргуулах гэж цайздаа дуудсан юм” - гэв.

Тэгээд Саруман дээрэнгүй дүртэй болж, урьдчилан бэлтгэсэн бололтой яриагаа эхэллээ: “Эхний эрин өнгөрлөө, Гэндальф. Дундад эрин ч төгсгөлдөө ойртож байна. Цоо шинэ эрин эхэлж байна. Газар дээр эльфүүдийн орших хугацаа дууссан, тоотой хэдэн хоног үлдсэн. Их ард түмний эрин эхэлж байна, бид түүнийг удирдах жамтай. Бидэнд бүх эрх мэдлийг бүгдийг нь булаах шаардлага байна. Яагаад гэвэл мэргэдээс мэргэн бид л хүмүүсийг амар тайван, аз жаргалтай амьдруулахын тулд амьдралыг яаж төвхнүүлэхийг мэдэх хувь тохиосон.

Сонсч бай, Гэндальф, миний найз бөгөөд туслагч, чамайг надтай хүчээ нэгтгэнэ гэж найдаж

байгаа болохоор би чи хоёрыг нийлүүлээд бид гэж хэлж байна. Газар дээр шинэ хүч гарч ирлээ. Түүний өмнө өмнөх холбоод юу ч хийх чадалгүй. Нуменорууд болон эльфүүдийн үе өнгөрлөө. Бидэнд сонголт байхгүй. Бид шинэ хүчийг дэмжих ёстой. Энэ бол мэргэн шийдвэр, надад итгэ Гэндальф минь. Түүнд л бидний цорын ганц найдлага байна. Шинэ хүчний ялалт ойрхон байна. Түүнийг дэмжигчдийг агуу их шагнал хүлээж байна. Шинэ хүчин мандан бадрахад холбоотнууд нь ч мандан бадарна. Чи бид хоёр шиг мэргэд аажмаар тэр хүчийг эрхэндээ оруулна. Бидний төлөвлөгөөг хэн ч мэдэхгүй, бид өөрсдийнхөө цагийг хүлээх л хэрэгтэй, эхэндээ бид шинэ хүчний хатуу харгис аргыг шүүмжилсэн ч болно, гэвч дотроо түүнийг эцсийн зорилго болгон дэмжих учиртай. Бүхнийг мэдэх, өөрийн засаглал, эмх журмыг дэмжих болно. Үүнийг бид эртнээс мөрөөдсөн, сул дорой, шал дэмий найз нар маань бидэнд тус болохоосоо саад болох нь их байсан. Бид зорилгоо өөрчлөх хэрэггүй, өөрчлөх ч үгүй, зөвхөн зорилгодоо хүрэх аргаа л өөрчилнө”.

“Одоо чи намайг сонс, Саруман – гэж би түүнийг дуугүй болохоор нь хэлээд - Бид ийм яриаг нэг бус удаа сонсч байсан, гэвч ийм үгийг Дайсны хэл ам бологч нар гэнэн тэнэгүүдийг хуурч мэхлэхдээ хэлдэг байсан. Чи арай тэдний чалчааг давтах гэж дуудаагүй юм байгаа биз дээ?” – гэж би асуулаа.

Тэр над руу нүд буландан хараад: “Тэгэхлээр чи мэргэдийн хувь заяаг дагахгүй юм шив дээ? Одоо ч гэсэн хэвээрээ юу? Хуучин арга хэрэгсэл юунд ч хэрэггүй гэдгийг чи ойлгохыг хүсэхгүй байгаа юм шив дээ? гээд Саруман миний мөрөн дээр гараа тавьж бараг шивнэх шахам хэлэхдээ: - Бид бүхнийг захирагч бөгжийг эзэгнэх хэрэгтэй. Тийм л учраас би чамайг дуудсан юм. Надад олон нүд, чих үйлчилдэг юм. Бөгж хаана хадгалагдаж байгааг чи мэдэж байгаа гэдэгт би итгэлтэй байна. Тэгээгүй сэн бол чамд Хоббитан ямар хэрэгтэй билээ? Яагаад хар морьгнууд тэнээд байгаа билээ?” гэж асуулаа. Саруман миний нүд рүү цоо ширтэж, тэрний нүдэнд нууж чадахын аргагүй шунал гялалзав.

Би жаахан ухрахаар шийдэж “Саруман, - бүгдийг захирагч бөгжинд зөвхөн нэг л эзэн байх ёстойг чи бид хоёр мэдэж байгаа, тийм учраас бид гэж ярих хэрэггүй. Одоо би нэгэнт чиний санааг мэдсэн болохоор би бөгжний талаар чамд нэг ч үг хэлэхгүй. Чи Зөвлөлийн тэргүүн мэргэн байсан, харин одоо бол мэргэн ч байж чадахгүй. Миний ойлгосноор чи намайг нэг бол Сауронд эсвэл Саруманд захирагд гэсэн сонголт санал болгож байх шиг байна. Би алинд нь ч захирагдахгүй. Өөр санал болгох юм байна уу?” – гэлээ.

Тэр над руу хүйтэн бөгөөд заналтайяа харж “Чи ядаж өөрийнхөө сайн сайхан байдлын төлөө мэргэдийн мэргэнийхээ ухааныг гаргана гэж би угаасаа найдаагүй юм аа. Гэхдээ чамд сонголт хийх боломж олголоо, харин чи адгийн тэнэг зөрүүд замаа сонголоо. Одоо яая гэхэв, эндээ байзнаж байхаас”.

“Байзнах гэдэг чинь юу гэсэн үг вэ?”

“Бөгж хаана байгаа надад хэлэх хүртлээ энд байна гэсэн үг. Эсвэл чамайг мунхаглан зөрүүдэлсээр байх хугацаанд бөгжийг эрж олох хүртэл. Тэр цагт гүрний эзэн хоёрдугаар зэргийн асуудлуудыг шийднэ. Жишээ нь Саарал Гэндальфыг зөрүүдэлснийх нь төлөө яаж шагнах вэ гэх мэт”.

“Шийдэх ч тэрэнд амархан байх л даа, харин шийдвэрээ яаж биелүүлэх юм бол доо?”

Намайг харуулын цамхагт аваачлаа. Сураман тэндээс оддыг ажигладаг юм. Тэндээс буух хэдэн мянган гишгүүртэй тахирласан шатыг харуулын отряд хамгаалж байх бөгөөд тэр шат нь дотоод ордон руу шууд ордог юм байна. Би ганцаараа үлдээд урьд нь цэцэг алагласан нуга байсан хөндийг харлаа. Одоо тэнд тийм нуга бараг алга, уурхайн хар амнууд, зэвсгийн үйлдвэрүүдийн налуу дээвэр, дээгүүр нь хөшиглөсөн хар утааг л харж байв. Хөндийн эргэн тойронд өндөр хадан хясаа байх тул салхи бараг орохгүй тул утаа эгц дээш хөөрнө. Ортханкийн цамхгийг хучсан утаан дотроос сүрэг чонодолоохууд, сайтар зэвсэглэсэн орхуудыг олж харав. Саруман өөрийн армитай болж байгаа юм байна, тэгэхлээр Дайсанд шууд захирагддаггүй гэсэн үг. Харуулын цамхаг их жижиг талбайтай тул алхаж гишгээд бүлээцэх боломжгүй, уулсын мөнх мөс доош хүйтнээр үлээж, хөндийд нойтон манан хөврөн байлаа. Гэвч хүйтэн, ганцаардал хоёроос өмнө Хоббитан даяар давхилдаж байгаа хар морьтнууд миний санааг их зовоож байв.

- Би чамайг харсан! - гэж Фродо дуу алдаад – чи шоронд хоригдож байгаа юм шиг урагшаа хоёр, хойшоо хоёр алхаад байсан, чиний дээрээс сарны гэрэл тусч байсан! гэв.

Гэндальф Фродо руу гайхан харлаа.

- Энэ бол зүүд байсан юм. Бүр аль эрт зүүдэлсэн боловч сая яг таг саналаа, би тэгэхэд дөнгөж Хоббитанаас явж байсан юм.

- Тиймээ, миний шорон гэрэлтэй байсан, гэхдээ надад хэзээ ч тийм баргар бодол орж ирж байгаагүй. Гэндальф би өөрөө урвагчийн торонд орчихсон байна гэж төсөөлөөд үз л дээ! Гэхдээ ямар ч бат бөх торноос гарах сул нүх байдаг юм даа.

Эхлээд би муу юм бодож, Радагаст Карийг урвасан байна гэж бодож байлаа. Саруман намайг яг ингэж бодно гэж тооцоолсон. Гэвч дараа нь Радагаст ярьсан яриагаа эргэж санаад Саруман түүнийг хуурсан байна гэж мэдлээ. Радагаст худлаа ярьж чаддаггүй учир тэр намайг хуурсан бол би тэр тор нь мэдрэх байсан. Радагаст надад худлаа яриагүй, тийм ч учраас би урхинд орсон. Би түүний үгэнд шууд итгэдэг юм.

Тийм ч учраас Саруманы хар санаат төлөвлөгөө нурсан. Радагаст амлалтаа биелүүлсэн тэр надаас салангуут дорно зүг явж, Манант уулсад очингуутаа уулын бүргэдүүдэд Гэндальфт тусал хэмээн тушаажээ. Тэднээс хэн ч нуугдаж чадахгүй. Үзэгдэх биегүй сүгнүүд ч, асар олон чонодолоохууд ч, Хорлумыг хулгайлахаар Балар шугуйд довтолсон орхууд ч бүргэдүүдийн нүднээс мултрахгүй.

Нэг шөнө уулын бүргэдүүдийн хамгийн хурдан Салхинжигүүр Изенгардад нисэн ирж, Ортханкийн дээрээс доошлоод, харуулын цамхаг дээр зогсч байгаа намайг харжээ.

“Би чамд чухал мэдээ авчирлаа” – гэж тэр хэлэв. Бүргэдүүдийн цуглуулсан мэдээг Салхинжигүүр надад дамжуулсны дараа би түүнээс:

“Чи намайг эндээс аваад явж чадах уу?” – гэж асуув.

“Чадна, хэрэв зам нийлэх юм бол. Намайг нааш нь элч зарж илгээсэн болохоос морь болгож явуулаагүй. Гэхдээ чамд морь хэрэгтэй байгаа бол би чамайг Эдораст хүргээд өгье, тиймхэн зайд зам муруйх надад юу ч биш” гэлээ. Үүнээс сайхан юмыг мөрөөдөөд ч хэрэггүй. Мустангримд амьдардаг ристанчууд эртнээс зэрлэг адуу сургаж ирсэн, маш хурдан, хүчтэй морьдтой тул би Хоббитанд хурдан хүрэх унаатай болно.

“Тэд Дайсны захиргаанд ороогүй гэж чи бодож байна уу?” – гэж бүргэдээс ямар ч гэсэн асуулаа. Учир нь Саруманы урвалт миний гэгээн хүчинд итгэх итгэлийг эвдсэн билээ.

“Ристанчууд Мордорт татвар өгдөг, жил бүр морьд өгдөг юм. Би тэгж сонссон, энэ бол холбоотондоо өгч байгаа бэлэг биш, татвар. Хэрэв чиний ярьж байгаагаар Саруман хар хүч болсон бол ристанчууд тусгаар тогтнолоо хамгаалж чадахгүй” гэж бүргэд хэлэв.

Салхинжигүүр Ристанийн тал дээгүүр нисч, Эдорас цайзаас холгүйхэн, Цагаан уулын баруун хойт үзүүрт буув. Саруман ристанчуудыг худал мэдээллээр төөрөгдүүлсэн учир Саруман урвасан гэж намайг хэлэхэд тэд үнэмшихгүй байлаа. Гэвч намайг Ристанаас хурдхан явуулахын тулд морь сонгож авахыг зөвшөөрөв. Би Мустангримын адуун сүрэг дотроос хамгийн хурдныг нь сонгосон тул тэд их гонсгор байлаа.

- Тэр бол үнэхээр гайхамшигтай адуу, Мордорын эзэн Дундад газрын хамгийн шилдэг морьдыг авч байгаа нь харамсалтай байна, гэхдээ энэ бол сүүлийн үеийн үйл явдлуудаас хамгийн харамсалтай нь биш, ристанчууд хэнд ч татвар төлж байгаагүй – гэж Арагорн хэлээд санаа алдав.

- Одоо ч гэсэн төлдөггүй – гэж Боромир ярианд оролцож –энэ бол Дайсны хорон санаат явуулга. Мустангримын ванг би мэдэлгүй яах вэ, манай үнэнч бөгөөд аймшиггүй холбоотон шүү дээ.

- Харанхуйн хөшиг өмнөдийн нэлээд газар нутгийг нөмөрлөө. Тэрний сүүдэрт Саруман төрлөө солилоо. Мустангрим ч харанхуйлсан байж болно. Чи үүнийг мэдэхгүй байна. Хэрэв өмнөд нутагт эргэж очиж чадвал мэдэх болно – гэж Арагорн хэлэв.

- Тийм юм л болохгүй шүү – гэж Боромир эсэргүүцээд – Мустангримчууд морьдоо барьж өгч тусгаар тогтнолоо худалдаж авахгүй. Тэд бол захирагчид. Тэдний морьд Дайсны харанхуй хөшигнөөс алс холд, умардын бэлчээрт бэлчиж байгаа, эзэд шигээ эрх чөлөөнд дуртай адуу даа.

- Гэвч миний сонгож авсан морь бусад адуутай харьцуулшгүй. Тэр бол хэзээ ч эцэшгүй хүчтэй, салхинаас ч хурдан, хар морьд түүний хаана ч хүрэхгүй. Ристанчууд түүнийг Үүрийнцолмон гэдэг юм. Өдөр мөнгөлөг сүүдэр мэт харагддаг, шөнө үзэгддэггүй, ялангуяа давхиж явахдаа огт харагдахгүй. Алхаа нь хөнгөн, харайлт нь гэрэл цахилгаан мэт хурдан, надаас өмнө түүний нуруун дээр салхинаас өөр юм гараагүй, би түүнийг сургаж, умар зүг давхисан, Фродо Булшны газарт хүрч явахад би Хоббитаний хил давж байлаа. Бид хоёр зэрэг гарсан шүү дээ. Тэр Норгордоос, би Эдорасаас гарсан.

Үүрийн цолмон умар зүг цуцашгүй хурдалж байхад би улам л сэтгэл зовнисоор байлаа. Хар

морьгнууд Хоббитанд хүрч, бидний хоорондын зай багассаар байсан ч тэд миний урд байлаа.

Удалгүй би морьгнууд хоёр салж, нэг хэсэг нь далд зам дайрч өнгөрдөг дорно хил дээр үлдэж, нөгөө хэсэг нь Хоббитанд өмнө талаас нь орж ирснийг мэдсэн юм. Фродо гэртээ байсангүй, цэцэрлэгч Скрамбиг удаан шалгаасан, хичнээн шалгаасан ч бага юм мэдэж авсан. Тэр нэг бол өөрийнхөө тухай, эсвэл Уутан хясааны шинэ эздийн тухай л яриад байлаа.

“Өөрчлөлт надад хортой, Би хөгшин хүн, муу тийшээ өөрчлөлт эрүүл мэндийг минь сүйтгэдэг” гэж тэр ярьсан. Муу тийшээ өөрчлөлт болж байна гэж тэр дахин давтан ярьж байв.

“Чи муу тийшээ өөрчлөлт үзээгүй байна, үзэхгүй байх гэж найдацгаая” гэж би хэлэв. Гэвч хөгшин хүний чалчаа үглээн дундаас би Фродо долоо хоногийн өмнө явсан юм байна, түүний явсан орой хар морьгнууд байшингийнх нь гадаа ирсэн юм байна гэж мэдэв. Бүрмөсөн сэтгэл гонсойсон би цааш хөдөллөө. Туулайн толгодын оршин суугчид үүрээ хөндүүлсэн шоргоолж шиг үймж байлаа. Молтогчингийн судаг дахь байшинд иртэл байшинг түйвээсэн, хоосон, үүдний довжоон дээр Фродогийн цув хэвтэж байлаа.

Өөр найдах юм үлдээгүй учир би хар морьгнуудын араас хөөхөөр шийдэж, нутгийн ардуудаас юу ч асуугаагүй юм. Асуусан бол санаа амрах байсан юм билээ.

Би Саруманд итгэхгүй байлаа ч гэсэн тэр үзэгдэх биегүй дайчдын тухайд худлаа хэлээгүй, тэгээд ч би зам зуураа тэдний тухай сонссон билээ. Би Хоббитанд байгаа найз нартаа их санаа зовж байсан ч гэсэн Фродо миний захиаг аваад нэг ч өдөр алгуурлалгүй Уудам хөндийд хүрсэн байх, дайснууд бөгжийг гартаа оруулаагүй байх хэмээн найдаж байв. Гэвч амьдрал бүгдийг өөрчилдөг билээ. Би мухлагийн эзний хичээнгүйд найдаж байсан ч Мордорын эзний сүр хүчнээс айж байлаа. Гэтэл Лавр миний захидлыг явуулахаа мартчихсан, хар эзний есөн хар морьт миний бодсоноос сулхан байжээ. Айдсын нүд том байдаг болохоор би Саруманы урхинд орж, хоригдон ганцаардаж, найз нарынхаа төлөө хэтэрхий санаа зовсондоо дайсны ухаан, хүчийг хэтрүүлэн үнэлжээ.

Дараа нь морьгнууд дахиад хоёр хэсэг салсан байлаа, би Уулын суурин руу явсан хэсгийн хойноос хөөхөөр шийдэв. Би Лаврыг сайн байцааж, юу болсныг мэдэх хэрэгтэй байв.

“За Лавр минь, хэрэв чи миний захиаг явуулаагүй бол би чамайг буцалж байгаа шөлөнд хийгээд жинхэнэ лаврын навч шиг чанана даа!” – гэж би замдаа бодож байлаа. Тэр үүнээс бага шийтгэл хүлээгээгүй бололтой, намайг харангуутаа намрын хуурай навч сэвэлзүүр салхинд чичирч байгаа юм шиг чичрэв.

- Чи түүнийг яасан бэ? - гэж Фродо яриаг нь таслав. Хөөрхий сайхан сэтгэлт мухлагийн эзэн түүнд хайран санагдав – Тэр биднийг дотнын найз шигээ хүлээж авсан, янз бүрээр тусалж байсан.

- Битгий ай - гэж Гэндалф инээмсэглээд – Би түүнийг айлгаж ч чадаагүй, яагаад гэвэл тэр чичрэхээ болингуут та нарыг Арагорнтай явсан гэж хэлсэн юм, тэгээд л би магнай хагартлаа баярласан.

- Тэнэмэлтэй цуг явсан уу? – гэж би түүнээс баяртайяа асуухад:

- Түүнтэй цуг, - гэж Наркисс миний уурыг улам их хүргэж байна гэж бодсон бололтой өгүүлээд - Энэ хүн чинь тэнэмэл амьтан гэж би тэдэнд хэлсэн шүү дээ. Гэвч тэд тун хачин загнаад байсан... нэг л хачин дураараа загнаад байсан.

- Миний хайрт тэнэг ээ! Миний сайхан илжиг ээ! – гэж би тэсвэр алдан хашгирч - Зуны дунд сараас хойш би ийм сайхан мэдээ сонссонгүй, тэнэг Лавр минь! өнөө шөнө би сайхан унтана, хичнээн сар унтаагүйгээрээ сайхан унтана!” - гэлээ.

Би Наркиссын дэн буудалд хонохдоо хар морьтнууд хаашаа алга болчихов гэж бодсоор байлаа. Уулын суурингийнхан ердөө хоёрыг л харсан гэж байгаа. Гэвч тэр шөнө байдал тодорхой болсон. Баруун өмнө зүгээс дахиад таван морьтон ирж, баруун хаалгыг зад татаж хаяад эрлэгийн таван элч мэт суурин дундуур давхилдаж, суурингийнхан үнхэлцгээ хагартал айж, энэ хорвоо ингээд л дууслаа гэж бодож байлаа. Өглөө нь би тэдний араас хөөв.

Би Хоббитанд тэднээс хожимдож очсон учир тэнд болсон үйл явдлыг ингэж бодож байна. Есөн бөгжтөний толгойлогч хоёр морьтонтойгоо өмнөд хил дээр отоонд суусан, хоёр нь Уулын суурин руу явсан, дөрөв нь Уутан хясаа руу яаран давхисан. Дараа нь тэд Уутан хясаанд ч, туулайн толгодод ч хэнийг ч олоогүй учир өмнөд хил рүү эргэжээ. Толгойлогч нь дөрвөн морьтноо зүүн хойт зүг рүү явуулаад өөрөө Баруун зам руу давхижээ.

Тэгээд би Арагорны явсан байх ёстой зүг рүү хөдөлсөн, хоёр дахь өдрөө Эргүүлэг ууланд хүрсэн боловч Дайсны зарц нар надаас өмнө тэнд хүрсэн байв. Тэд надтай тулалдахаас айсан болохоор би уулан дээр саадгүй гарсан боловч харанхуй болохоор тэд зориг орж, би тэднийг хөөж явуулах гэж багагүй хөдөлмөрлөсөн. Эргүүлэг уулан дээгүүр аянга бууж, цахилгаан цахилж байсан ч тэр шөнө шиг гэрэлтэй байгаагүй гэж би бодож байна.

Өглөө нь би Уудам хөндий рүү орохоор шийдсэн, гэхдээ шууд биш, хойт талаас нь тойрч орохоор шийдсэн юм. Фродог өрмийн толгойд хайж, харанхуй шөнөөр хар морьтнуудтай тулалдах нь ашиггүй бөгөөд тэнэг хэрэг болох байсан. Хэрэв би хоббитуудыг олчихвол дайсны отрядыг бүхлээр нь араасаа дагуулж очих байсан. Тиймээс би Арагорнд бүрэн итгээд хойт зүг рүү эргэсэн. Хар морьтнуудын хагас нь миний араас хөөнө гэж би тооцоолсон бөгөөд би тойруу замаар тэднийг төөрүүлээд Уудам хөндийн хойт талаас нь орж ирээд эльфүүдийн хүчирхэг баг цэрэгтэй хүч хавсран хар морьтнуудыг хэсэг бусгаар нь устгана гэж төлөвлөсөн юм. Гэвч намайг хөөж явсан дөрвөн хар морьт хэд хоногийн дараа хаа нэг тийшээ алга болсон, тэд Гарам руу явсныг би сүүлд нь мэдэж Арагорн руу таван хар морьт дайрахад би тусалсан юм.

Ингээд миний илтгэл дуусч байна. Би дэндүү урт түүх ярьсан учир эрхэм зочид болон, хүндэт эзэн намайг өршөөгөөрэй. Гэвч бөгж хадгалагч ямар учраас цаг тухайд нь тусламж авч чадаагүй, мэргэдийн мэргэн, агуу шидтэн Саарал Гэндалф ямар учраас андгайгаа анх удаа зөрчсөнийг яг таг мэдэх шаардлагатай учир би ингэж их нуршлаа.

Ингээд та бүхэн бөгжийг анх давтсанаас өнөөдрийг хүртэлх түүхийг бүрэн сонслоо. Гэвч бид зорилгодоо нэг ч алхам ойртсонгүй. Одоо бид бөгжийг яах вэ гэдгээ хэлэлцэн шийдэх

хэрэгтэй байна – гээд Гэндальф яриагаа дуусгав.

Зочид хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй сууцгаана. Эцэст нь Элронд нам гүм байдлыг эвдэж:

- Чи бидэнд гашуун түүх ярилаа, Гэндальф. Мэргэд Саруманд бүрэн итгэдэг болохоор бидний бүх төлөвлөгөөг тэр мэдэж байгаа. Дайсны хорон санаат төлөвлөгөөг мэдэх тусам тэрний хорон санаанд өөрийн эрхгүй ордгийг чиний яриа нотоллоо. Урваж төрлөө солих гэдэг шинэ юм биш, аль эртний юм. Харин өнөөдрийн ярианаас миний сэтгэлийг хамгийн их хөдөлгөсөн зүйл бол намхан эр Фродогийн эр зориг, эрэлхэг гавьяа юм. Би ердөө ганцхан намханыг, Бильбог л таньдаг, тэр амар амгалан Хоббитаныхаа оршин суугчдаас нэг их ялгарахгүй юм байна. Намайг баруун газарт байх хойгуур ертөнцөд их өөрчлөлт гарсан бололтой.

Үхдэл сүгнүүдийг бид олон нэрээр мэднэ. Өнөөгийн Мөнхийн ойн тухай домгуудад түүнийг төгсгөлгүй гэж нэрлэдэг, миний ойлголтоор бол тийм ч их эрт дээр биш үед модноос модонд харайсан хэрэм өнөөгийн Хоббитанаас манант ууланд буудаг байсан. Би мөнхийн ойгоор аялж явахдаа олон хачирхалтай юм үзсэн.

Баруун газрын эзэн буюу хамгаалагч Бомбадилтай эльфүүдийг хувь тавилан учруулсан, тэр үед Дундад газар идэрхэн ч байсан, сайхан ч байсан, бид түүнийг Йарвен Бен-Адар буюу Баруун газрын эцэг гэж нэрлэдэг байсан, нуменоруудын удам түүнийг Оральд гэж нэрлэдэг байсан... Би түүнийг Зөвлөлд уриагүй буруудсан юм биш биз?

- Тэр ирэхгүй байсан - гэж Гэндальф хариулав.

- Урилга явуулбал яасан юм бэ? Эсвэл зүгээр л тусламж гуйвал ямар вэ? - гэж Эрестор саналаа хэлээд – миний ойлгосноор бол тэр дайсны бөгжийг хүртэл захирч чадах юм биш үү?

- Чи бүрэн ойлгоогүй байна, түүнийг Дайсны бөгж захирч чадахгүй гэж хэлбэл ононо. Йарвен өөрөө өөртөө эзэн бөгөөд захирагч. Гэвч тэр бөгжинд тушаал өгч чадахгүй, бөгжнөөс бусдыг хамгаалж ч чадахгүй. Тэр өөрийнхөө дархан цаазат хязгаарт бүтсэн, сайн дураараа хэзээ ч тэндээс гарахгүй.

- Гэвч тэр өөрийнхөө заагласан хил хязгаарт бүхнийг захирагч эзэн хэвээрээ байгаа. Тиймээс тэр бөгжийг хадгалж болох юм биш үү?

- Сайн дураараа авахгүй - гэж Гэндальф хэлээд – мэргэдийн гуйлтаар авлаа гэхэд бөгжийг ямар ч хэрэггүй эд гэж хандах болно. Хэд хоноод л мартчихна, аягүй бол гаргаад шидчихнэ. Тэр дайны төгсгөл ямар болохыг сонирхохгүй учраас тун ч найдваргүй хадгалагч, тиймээс бөгжийг түүнд даатгаж болохгүй.

- Ямар ч тохиолдолд бид ялагдах өдрөө л хойшлуулна. Йарвен Уудам хөндийгөөс алс холд амьдардаг. Бид хар эзний тагнуулуудад мэдэгдэхгүйгээр бөгжийг тийш нь аваачиж чадахгүй. Чадлаа ч гэсэн Саурон эрт орой хэзээ нэгэн цагт бөгж хаана хадгалагдаж байгааг мэднэ, тэгээд дархан газар руу хамаг байдаг хүчээ хаяна. Тийм дайнаас Йарвен тэсээд гарч чадах уу?

Би л лав эргэлзэж байна. Гэгээн хүчнүүд устгагдсан хойно Йарвен ч унана, энэ ертөнцөд нэгэн цагт хамгийн түрүүнд ирсэн шигээ хамгийн сүүлд буцах болно, Дундад газрыг харанхуйн хар хөшиг бүтээнэ – гэж Асалдар ярив.

- Би Йарвеныг мэдэхгүй ч гэсэн түүний тухай сонссон. Миний бодлоор бол Асалдарын түмэн зөв. Хэрэв дайсны хар хүчийг ялан дийлэх хүч ертөнцөд байгаа гэж бодоход ямар ч гэсэн тэр нь Йарвены дархан газарт байхгүй. Бидний мэдэж буйгаар Дайсан онгон байгалийг ч захирах хүчтэй шүү дээ. Зөвхөн онгон төрмөл хүч л Сауроныг дийлж чадна гэж би бодож байна. Ийм хүч та нарт байгаа юу?

- Миний хүч хүрэхгүй- гэж Элронд хариулав.

- Трандуилд ч тийм хүч байхгүй – гэж Леголас дуугарав.

- Би Сэрдана Корабелын зөнч биш, гэхдээ бид Дайсныг дийлэхгүй байх гэж би айж байна гэж – Гэлдор хэлэв

- Хар эзэн бидэнд нэгдэх боломж олгохгүй, манай газар нутаг хар цэргийн далайгаар хүрээлэгдсэн арал болно - гэж Элронд энэ гашуун яриаг дуусгав.

- Бид бөгжийг дайснаас хамгаалж чадахгүй, тиймээ бидэнд хоёр л зам үлдлээ. Нэг бол бөгжийг далайн чанад гаргах, эсвэл устгах – гэж Асалдар хэлэв.

- Гэндалф бидэнд бөгжийг зөвхөн Мордорт л устгаж болохыг нээж өгсөн, далайн чанадах ардууд бөгжийг хүлээж авахгүй, бөгж Дундад газарт л хамаарна, тиймээс манай газрыг орхихгүй – гэж Элронд сануулав.

- Тэгвэл далайн ёроолд хийчихье л дээ, Саруманы худал яриаг ингэж илчилье. Тэр өмнөх зөвлөл дээр худлаа ярьсан, тэр эрх мэдэлд шунаж, бүгдийг захирагч бөгж олдсоныг мэдсэн учраас мэргэдийг төөрөгдөлд оруулсан. Гэвч далайн ёроол бол найдвартай бунхан, бөгж тэнд үүрд үлдэнэ – гэж Асалдар санал болголоо.

- Харамсалтай нь далайн ёроолд ч амьтад бий, тэд Хар эзний дуулгавартай зарц болно. Хамгийн гол нь одоо ус байгаа газар нэгэн цагт хуурай газар болж мэднэ, тиймээс Дундад газрын мэргэд бид бөгжний хувь заяаг нэг жилээр, хэдэн үеэр, тэр ч байтугай хэдэн эринээр алга болгох биш, үүрд алга болгох ёстой.

- Дархан газарт хүрэх зам аюултай бол далай хүртэлх зам бүр ч аюултай. Дайсан бөгж хаана байгааг мэдмэгц биднийг баруун зам дээр тосно. Тагнуул туршуулууд нь энэ талаар тодорхой мэдээ өгнө. Урьд нь тэднийг яаран сандран явуулсан, тэд зугтаасан, одоо Саурон тэдэнд өмнөхөөс илүү хүч чадалтай, илүү хурдан, илүү тэсвэртэй морьд өгнө. Дайсны цэргийн манлайд есөн морьтон гарахад Гондор бүрэн бут ниргэгдэнэ, тэгээд Дайсан хойт зүг хөдөлж эльфүүдийн баруун нутгийг эзэлнэ.... гэж Гэлдор хэлэхэд Боромир:

- Чи Гондорыг тийм амархан бут ниргүүлнэ гэж бодож байна уу, түүнийг бут ниргэх тийм амаргүй байлгүй! Бид эцсийн хүчээ шавхан тэмцэж байна гэж би хэлсэн, гэхдээ манай

эцсийн хүч дайсны шинээр эмхэлсэн армид ч тийм амархан дийлдэхгүй шүү - хэмээн уурсав.

- Морьтнууд байхгүй сэн бол дийлдэх ч үгүй - гэж Гэлдор тодруулаад – гэхдээ дайсан Гондорыг заавал эзлэх шаардлагатай. Тэр тойруу зам олж, гол хүчээ хойт зүг рүү хөдөлгөн та нарыг Дундад газраас таслаад танай баруун ба хойт хил дээр хүчтэй хамгаалалт тавьж ч болох юм.

- Тийм бол дөнгөж сая Асалдарын хэлснээр бидэнд хоёрхон зам байна. Тэр хоёр замын аль аль нь мухар зам. Мөн ч хэцүү асуудал байна даа – гэж Эрестор бухимдахад:

- Гэхдээ бид энэ асуудлыг шийдэх ёстой – Элронд баргар царайлсан мөртөө тайвнаар өгүүлээд – Бидэнд аль зам аюул багатай вэ? Далай хүрэх баруун зам уу, Мордор хүрэх өмнөд зам уу? Гэвч эльфүүд ямагт баруун зүг ухардгийг дайсан сайн мэдэж байгаа. Тиймээс баруун замаар юу ч гаргахгүй байх арга хэмжээ авна. Тиймээс бидний эцсийн найдвар бол Дайсны санаанд оромгүй шийдвэр гаргах. Зэвсгийн уул руу хүрэх зам бол бидний эцсийн найдвар. Бөгжийг галд өргөх хэрэгтэй.

Танхимд нам гүм болов. Цонхны цаана нар гийж, мөрөн гол намуухан урсаж байсан ч Фродогийн зүрхийг хар айдас мөсөн бахиар хавчих мэт санагдав. Боромир хөдлөх шиг болоход тэр гондор эр рүү найдвар тээсэн харц чулуудлаа. Гэвч гондор анчны эвэр бүрээгээ оролдон баргар царайлж суув. Тэгснээ:

- Та нар юунаас айгаад байгааг би ойлгохгүй байна. Саруман урвасан л юм биз, гэвч та нарын хэн ч тэрнийг тэнэг гэж бодохгүй байна. Дайсны бөгжийг зөвхөн нуух юм уу, устгах хэрэгтэй гэж та нар ямар учраас бодож байгаа юм бэ? Нэгэнт тэр бөгж та нарын гарт байгаа юм бол тэрнийг дайсны эсрэг ашиглах хэрэгтэй юм биш үү? Бөгж Дайсныг устгаж чадна, тийм ч учраас дайсан бөгжнөөс айж байгаа шүү дээ! – гэж шийдвэртэй хэлэв.

- Гондорын ард түмнийг гартаа оруулах боломжгүй, гэвч биднийг хүйс тэмтрэх аюул нүүрлэж байна. Шийдвэрлэх тулалдаан тулж ирэхэд эр зоригтон яаралтай зэвсэглэдэг. Бөгж тийм агуу их хүчтэй л юм бол бидний зэвсэг болог л дээ!

- Бүгдийг захирагч бөгжийг гэгээн хүчин ашиглаж болохгүй. Үүнийг бид дэндүү сайн мэднэ. Бөгжийг хар эзэн хар санаагаа гүйцэлдүүлэх гэж бүтээсэн юм. Бөгж агуу их хүчтэй, тиймээс үнэхээр хамгийн агуу хүчтэн л түүнийг эзэмшиж чадна. Гэвч бөгж агуу хүчтэнд бүр ч их аюултай. Цагаан Саруман тэрнийг эзэмших гэж санаархангуут төрөл арилжсаныг сана, Боромир. Хэрэв мэргэдийн нэг нь бөгжний тусламжаар Сауроныг дийлэх юм бол өөрөө Хар эзэн болж хувирна гэдгийг бид мэдэж байна. Энэ бол бөгжийг устгах нэг чухал шалтгаан байгаа юм, бөгж байгаа цагт мэргэдийн мэргэд хүртэл бүгдийг захирах эрх мэдлийн боол болох аюул байна. Хар Сауронд хар төрөөгүй. Би дайсны бөгжийг хадгалахаас айж байна. Тэрнийг би хэзээ ч тэмцэлд ашиглахгүй.

- Би ч гэсэн - гэж Гэндалф тод хэлэв. Боромирын нүдэнд үл итгэх байдал гялсхийсэн боловч үг дуугаралгүй тонгойв. Тэгээд:

- За тийм болог, ингэхлээр Гондорын дайчид бид зөвхөн өөрийнхөө зэвсгэнд найдах хэрэгтэй

боллоо. Мэргэд Дайсны бөгжийг хамгаалж байх зуур бид Дайсны цэргийг тогтоож байя. Магадгүй Элендилийн илдийг өвлөсөн хүн хугархай илднээс өөр юм өвлөөгүй бол... тэр илд Гондорын дайснуудын толгой дээр аянга болон буух ч юм билүү...

- Илдийг тулаанд шалгах өдөр ирнэ ээ – гэж Арагорн хэлэв.

- Тэр өдөр оройтохгүй байгаасай гэж найдъя. Бид тусламж гуйгаагүй, гэвч бидэнд тусламж хэрэгтэй байна. Түүнээс гадна Дайсантай гондорчууд бид дангаараа тэмцээгүй гэсэн итгэл бас хэрэгтэй байна...

- Тэгж найдаж болно, Дундад газарт гондорчуудын мэдэхгүй их хүчин олон бий. Тэд бүгдээрээ Дайсны эсрэг тэмцэж байгаа – гэж Элронд тайван хэлэв.

- Гэвч тархай бутархай тэр хүчнүүд нэгдвэл сайн сан. Тийм ч аймаар аюултай биш бусад бөгжнүүд бидэнд тус болно байх. Харамсалтай нь долоон бөгж алдагдсан... Хэдийгээр Балин Казад-Дум руу явахдаа Трорын бөгж олдоно гэж найдаж байсан ч...- гэж Глоин хэлэхэд Гэндальф:

- Дэмий найдаж дээ, бөгжийг түүний хүү Траин өвлөсөн, гэвч Трорын ач хүү Торинд бөгж өвлөгдөөгүй, түүнийг Траинаас Дул-Гулдурт булааж авсан...

- Хараал идсэн шидтэнүүд! – гэж Глоин дуу алдаад - Хэзээ бид тэднээс өшөөгөө авах юм бэ? Гэхдээ гурван бөгжийг Дайсан авч чадаагүй биз дээ? Эльфүүдийн шидэт гурван бөгжийг? Тэр бөгжнүүд маш их хүчтэй гэгцгээдэг шүү дээ. Тэднийг ч гэсэн Саурон хийсэн, эльфийн хаад тэр бөгжнүүдийн ид шидээс айдаггүй гэсэн. Тэдний тусламжаар Дайсныг хазаарлаж болохгүй гэж үү?

- Чи миний үгийг ойлгоогүй гэж үү, гном Глоин? – гэж Элронд хэсэг зуур дуугүй сууж байснаа хэлээд – Эльфүүдийн бөгжнүүдийг Дайсан хийгээгүй. Барааг нь ч хараагүй. Элфүүдийн бөгж зөвхөн эльфүүдэд л захирагдана. Гэхдээ дайны талбарт хэрэг болохгүй. Тэр бөгжнүүдийн тусламжаар алж ч болохгүй, хазаарлаж ч болохгүй, тэд ертөнцийг таньж, сайн үйл хийж, Дундад газарт эрх мэдлийн төлөө дайн эхлэхэд оршин суугчдынх нь зүрхэнд үүссэн хар муу санааг арилгахад тусалдаг юм. Дайсан бөгжөө алдсанаас хойш бид Хар муу санааг ялж байсан, хэрэв тэр бөгжөө дахиад гартаа оруулбал бидний бүх санаа бодлыг мэдэж, бид чөлөөт сэтгэлгээгээ алдана, хар хүчнүүд ялагдашгүй болно, Дайсан ингэхийг л хүсч байгаа юм.

- Тэгвэл бүгдийг захирагч бөгж алга болсны дараа ертөнц хэрхэн өөрчлөгдөхийг хэлж өгнө үү?

- Мэдэхгүй - гэж Элронд гунигтайяа хариулаад – Дайсан хэзээ ч харж байгаагүй гурван бөгж дайны үеэр ертөнцөд учирсан зовлонг арилгахад тусална гэж зарим хүн найдаж байгаа, ийм найдвар биелэхгүй болов уу гэж би айж байна. Бүгдийг захирагч бөгжийг устгаснаар бид бусад бөгжний хүчийг алга болгоно, тэгээд өнөөгийн энэ ертөнцийн гайхамшигт ид шид зөвхөн өнгөрсөн үеийн тухай үлгэр домогт л үлдэнэ гэж би бодож байна...

- Гэвч эльфүүд Дайсныг бүрэн ялахын тулд ямар ч гэсэн энэ бөгжийг устгахад бэлэн байгаа шүү дээ – гэж Асалдар хэлэв.

- Тэгэхлээр бидэнд ердөө ганцхан зам байна, тэр зам хаашаа ч явахгүй мухар зам. Бид Галт ууланд хүрч чадахгүй. Элронд мэргэн гэдгийг бид бүгд мэднэ, ялалтад хүргэх ганц замыг хэн ч мунхаг ухааны зам гэхгүй... гэвч тэр замыг туулах боломжгүй, ингээд бид гарцаагүй ялагдана гэсэн үг шив дээ – гэж Эрестор хэлэв.

- Хэн яагаа ч үгүй байхад итгэл алдарч цөхөрнө, түүнийг ялагдал хүлээж байдаг - гэж Гэндальф эсэргүүцээд... – Бусад бүх зам хаагдсан цагт аюултай замаар явах нь гарцаагүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь жинхэнэ мэргэн ухаан. Мордор руу явах мунхаг явдал шиг санагдаж байна уу? Тэгвэл ийм мунхаг явдал бидний баг, Дайсны нүдийг хаасан хөшиг болол дээ. Тэр заль ухаантай, дайсныхаа санааг тааж чаддаг боловч бүхнийг захирах эрх мэдлийн шунал нь шатааж байгаа, тэр бусдыг зөвхөн өөрөөрөө хэмждэг. Ертөнцийг захирах эрх мэдлийг үл тоомсорлох бодол түүний толгойд орж ирэх ч үгүй, бидний Мордор руу явж бөгжийг устгах шийдвэрийг тэр яасан ч таахгүй, бидний энэ шийдвэр тэрнийг бүрмөсөн төөрүүлнэ.

- Юу болоод байгааг тэр эхэндээ ойлгохгүй гэж би бодож байна. Мордор хүрэх зам маш аюултай, гэвч энэ бол ялалтад хүрэх цорын ганц зам – гэж Элронд өгүүлээд - Саурон өөрийн орондоо бүхнээс хүчтэй, тиймээс Мордор руу явж байгаа хүнд хүч, мэргэн ухаан хоёр давуу тал биш, нууц байдал л давуу тал болно. Энэ л хамгийн чухал, тиймээс энэ үүргийг хүчтэй хүнээс сул дорой хүн ч илүү сайн гүйцэтгэж магадгүй, яагаад гэвэл хүчтэй хүн аюулаас айдаггүй, Дайсантай тулалдвал сүйрнэ. Сул доройчууд нэг бус удаа хүчтэний хүч хүрээгүйг эр зоригтой, үнэнч шударга биелүүлж, ертөнцийг өөрчилж байсан удаа цөөнгүй.

- Би бүгдийг ойлгож байна – гэж Бильбо гэнэт хэлээд – эрхэм хүндэт Элронд цааш нь ярихгүй байж болно. Би энэ аюултай түүхийг эхэлсэн, одоо дуусгах нь миний үүрэг. Би эльфүүдийн дунд сайхан амьдарч байлаа, миний бүтээл ч дуусах дөхөж байлаа. Би мөдхөн бичиж дуусгана гэж бодож байсан, тэгээд л ... “Тэр амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл аз жаргалтай амьдарчээ” гэж төгсгөх юм шиг санагдаж байсан. Миний бодлоор энэ бол ер бусын гэж хэлэхэд хэцүү ч гайхамшигтай төгсгөл. Гэвч одоо ийм төгсгөл өөрчлөгдөх юм шиг байна, наанадаж хойшилно. Яагаад гэвэл ном зузаарна. Жаахан харамсалтай л байна!.. Тэгээд би хэзээ замд гарах вэ?

Боромир Бильбо руу гайхан харсан боловч Зөвлөлийн бусад оролцогчид өвгөн хоббитыг хүндэтгэн сонсч байгааг хараад доогтой инээмсэглэлээ нуулаа.

- Тийм ээ найз минь, - гэж Гэндальф хэлээд – Хэрэв энэ түүхийг чи эхэлсэн бол чи дуусгах ёстой байсан. Гэвч түүхийг ганцаараа эхлэх боломжгүй гэдгийг түүх бичигч мэдэх байлгүй. Хамгийн мэргэн, хамгийн агуу хүчирхэг баатар ч ертөнцийг өөрчлөгч түүхэнд өчүүхэн хувь нэмэр оруулдаг. Санаа зовох хэрэггүй дээ. Чиний тоглож хэлсэн энэ үгний цаана эрэлхэг зориг байгааг бид цөм ойлгож байна. Чи Галт уулан дээр гарч чадахгүй. Гол нь бөгж одоо шинэ хадгалагчтай болсон шүү дээ. Тийм учраас номынхоо төгсгөлийг өөрчилсний хэрэггүй. Эр зоригтнуудыг эргэж ирэхээр үргэлжлүүлж бичихэд бэлдэж бай.

- Тайван амьдраад сууж бай гэсэн зөвлөгөө чамаас сонсч байгаагүй юм байна шүү! - гэж Бильбо эгдүүцсэн байртай хэлээд - Чиний өмнөх зөвлөгөөнүүд мэргэн байсан, саяны зөвлөгөө чинь тэнэг битгий байгаасай... Яг үнэнээ хэлэх юм бол бөгжийг дахиад хадгалах хүч ч алга, аз ч байхгүй биз. Бөгжний хүч нэмэгдэж байна, би хөгширч, доройтож байна. Гэвч чи хэнийг эр зоригтон гэж хэлэв?

- Бөгжийг аваад Мордор руу явах хүмүүсийг.

- Надтай хүүхэдтэй ярьж байгаа юм шиг бүү ярь. Чухам хэнийг явуулна гэж шийдэв? Миний бодлоор бол өнөөдөр Зөвлөлийн шийдэх ганц асуудал энэ л байна. Эльфүүдэд хоол өгөөд хэрэггүй, чөлөөтэй л яриулах хэрэгтэй гэдгийг би мэднэ, гномууд тэвчээртэй хэдэн долоо хоног хоолгүй явсан ч чадна, харин би бол ердөө л хөгшин хоббит, одоо ч гэсэн өлссөндөө толгой эргэж байна. Тэгэхлээр зоригтнуудаа нэрлэе, эсвэл хоолны завсарлага авья!

Бильбо ингэж хэлсний дараа танхимд нам гүм болов. Зочдын хэн нь ч дуугарсангүй. Фродо бүгдийг тойруулан харахад хэн ч өөдөөс нь харсангүй, бүгд өөр өөрийн бодолдоо автан шал ширтжээ. Фродо одоо босоод хэлэх үгнээсээ айх шиг болов. Уудам хөндийд сайхан амарч, тайван амьдарч болохгүй гэж үү? Энд Бильбо байна, хичнээн тав тухтай, сайхан байна...

- Би бөгжийг тийш нь аваачихад бэлэн байна, Мордорт хүрч чадах эсэхээ мэдэхгүй байгаа ч гэсэн бэлэн байна – гэж тэр хэлэв.

Элронд Фродог анхааралтай харлаа.

- Миний ойлгож байгаагаар чи л үүнийг хийх тавилантай, хэрэв чи Мордорт хүрч чадахгүй бол харанхуйн хар хөшиг Дундад газрыг нөмөрнө. Амгалан тайван Хоббитаны намхан хүмүүсээс Дундад газрын хувь заяа хамаарч байна, хэрэв чи өөртөө үүрч байгаа ачаагаа дийлэх юм бол та нарын өмнө бат бэх цайзууд нурж, агуу мэргэд тэднээс зөвлөгөө авахаар очно...

Энэ бол хүнд ачаа шүү Фродо. Хэн ч бусдын мөрөн дээр буулгахааргүй тийм хүнд ачаа. Чи нэгэнт өөрийнхөө хувь заяаг сонгосон болохоор би чамайг зөв сонголт хийлээ гэж хэлье.

- Та түүнийг ганцааранг нь явуулахгүй биз дээ? Үгүй биз дээ, ноён Элронд? - гэж Сэм гэнэт хашгираад сууж байсан булангаасаа үсрэн босч ирэв. Зөвлөл эхлэхийн өмнө тэр буланд шалан дээр сууж авсан ажээ.

- Мэдээж үгүй - хэмээн Элронд сандарсан Сэм рүү инээмсэглэн хараад - Чи заавал хамт явна. Чи нууц Зөвлөлд хүртэл түүнийг дагаад ороод ирчихсэн юм чинь бид чамайг яалаа гэж эзнээс чинь салгах билээ?

Сэмийн царай улайж, даруйхан буландаа нуугдав.

- Ээ дээ, ноён Фродо, - бид хоёр энэ аймшигтай тоглоомд дэмий л орооцолдлоо доо! – гэж тэр толгой сэгсрэн үглээд дахин шалан дээр суулаа.

Бүлэг 15

Өмнө зүгт

Орой нь хоббитууд Бильбогийн өрөөнд цугларч өөрсдийнхөө нууц зөвлөлгөөнийг хийв. Мерри, Пин хоёр Сэмийн хийсэн “хэргийн” тухай сонсоод ихэд эгдүүцэв.

- Шударга ёс хаа байна? Энэ нөхрийг танхимаас хөөж гаргасангүй, өөрөө өөрийгөө өндөрт гаргасных нь төлөө гинжилж уясангүй, харин ч шагнаж Фродотой явуулж байдаг! – гэж Пин уурсав.

- Шагнасан гэнэ! - гэж Фродо гунигтайхан жуумалзаад – Аймшигтай шийтгэл оноосон гэж хэлээч. Бөгжийг аваад Мордор явна гэдэг шагнал юм уу, бодож яриач! Бөгжийг надаас салгаж авна, би Уудам хөндийд сайхан амарна гэж найдаж байсан юмсан.

- Тиймээ, эльфүүдэд зочлуулах Мордор руу тэнэснээс сайхан л даа – гэж Мерри зөвшөөрөөд – Гэвч бид чамд биш, Сэмд атаархаж байна. Нэгэнт чи энэ ажилтай зууралдсан юм чинь аян замд ганцаараа гарах чинь бидэнд хамгийн хүнд шийтгэл юм шүү дээ. Замын хагасыг бид хамтдаа туулсан юм чинь хамтдаа л дуусгах хэрэгтэй - гэв.

- Би ч тэгж бодож байна. Хоббитууд бид салж болохгүй. Намайг энд хорьчихдоггүй л юм бол би Фродотой хамт явна. Ядаж ганц ухаантай хүн түүнийг дагаж явах хэрэгтэй биз дээ!

- Энэ ажилд чи яагаад ч тохирохгүй – гэж Гэндальф цонхоор харангаа хэлээд – Та нар хэтэрхий эрт догдолж байна, одоохондоо юу ч шийдээгүй байна шүү дээ.

- Юу ч шийдээгүй гэнэ ээ? – Тэгвэл та нар тэр зөвлөл дээрээ юу хийсэн хэрэг вэ? – гэж Пин асуув.

- Ярьсан, сонссон - гэж Бильбо түүнд тайлбарлаад – Хүн бүр өөрийнхөө мэдэх юмыг ярьж, мэдэхгүй юмаа сонссон. Бүгд бие биеийнхээ яриаг амаа ангайж сонссон. Энүүхэндээ гэхэд бүхнийг мэддэг Гэндальф хүртэл Хорлум оргосон тухай санамсаргүй мэдээ сонсч балмагдсан, харин балмагдсанаа мэдэгдээгүй.

- Чи ташаарч байна. Энэ мэдээг надад Салхинжигүүр дуулгасан. Хэрэв мэдэхийг хүсч байвал зөвлөл дээр Бильбо, Фродо хоёр л амаа ангайн сонсч байсан, харин би ямар ч шинэ юм сонсоогүй.

- Юу ч сонсоогүй бол сонсоогүй л биз – гэж Гэндальфтай маргаад ямар ч хэрэггүйг мэдэх Бильбо зөвшөөрөөд – гэвч Зөвлөл дээр өдөржин ярьж, сонсоод зөвхөн Фродо, Сэм хоёрын тухай л асуудал шийдсэн. Хөөрхийст хэцүүхэн хувь тохиолоо доо.... гэхдээ тэд өөрсдөө сонгоогүй юм шүү. Хэрэв намайг л явуулахгүй юм бол Фродог явуулна гэдгийг би мэдэж байсан. Нэг нууц задлахад зөвхөн энэ хоёр явахгүй, бөгжтэй хамт том бүлэг явна. Тагнуулчдыг Уудам хөндийд ирмэгц хөдөлнө, тагнуулчид явчихсан биз дээ, Гэндальф?

- Зарим нь явсан, зарим нь өглөө гарах гээд цугларч байна. Тэдэнд умардын мөрчид, бас Трандуилын эльфүүд тусална гэсэн. Та нар тагнуулчдыг ирсний дараа хөдөлнө, тэгэхлээр Фродо сайхан амарч амжина.

- Мордорт өвөл л очих нь дээ гэж Сэм урам муутай бувгнав.

- Тэгэх л болж дээ, үүнд Фродо ч бас буруутай – гэж Бильбо хэлээд – яах гэж миний төрсөн өдрийг хүлээдэг байна аа? Тэгэхдээ хачин тэмдэглэсэн байгаа юм. Төрсөн өдрөөр минь миний эдлэн, өргөөг нойтон хамуу шиг муусайн Лякошель-Торбинс? Яалаа ч гэсэн нэгэнт хийсэн юмыг яая гэхэв, хавар болтол хүлээх аргагүй, тагнуулчдыг ирэхээс өмнө явах тэнэг хэрэг болно.

Намрын нулимсан завсраар

Хүйтний ам ангайхад,

Хүйтэн шөнийн цагаар

Хөвчийн зам аюултай ч

Тандаагүй зам бүр ч аюултай.

- Бильбогийн зөв гэж бодож байна - гээд Гэндальф – Бид хар морьтнууд хаана явааг эхлээд мэдэх ёстой.

- Тэд чинь үхээгүй юм уу? - гэж Мерри асуув.

- Тэдний эзнийг устгаагүй цагт тэднийг устгах боломжгүй. Тэд сүүлээ хавчаад зугтаж арилсан гэж найдаж байна, морьгүй болохоороо тэд манай газар нутагт ямар ч хүчгүй, гэхдээ үүнийг заавал шалгах хэрэгтэй. Одоохондоо айдсаа март, Фродо минь. Миний хэрэг болох юмуу, үгүй юу мэдэхгүй л байна, гэхдээ би чамтай хамт Мордор руу явна, сая Пиний хэлснээр чамд ухаантай дагуул хэрэгтэй.

Фродо туйлгүй их баярлаж, баяр хөөрөө нуусангүй тул Гэндальф малгайгаа авч мэхийн ёслоод:

- Би чамтай хамт явна гэж бодож байгааг анхааралдаа аваарай. Бид эцсийн шийд гаргаагүй байна. Элронд, Арагорн хоёр юу гэхийг мэдэхгүй. Ингэхэд би Элрондтой ярилцах хэрэг байна - гээд Гэндальф малгайгаа өмсөөд гарч одов.

- Бид хэдий хэр хүлээх бол, чи юу гэж бодож байна?

- Мэдэхгүй ээ, энд цаг өнгөрч байгаа нь бараг мэдэгддэггүй юм. Гэвч тагнуулчдын явах зам амаргүй болохоор чи тийм хурдан явахгүй болов уу. Тэр хүртэл бид хоёр ханатлаа ярьж амжина. Чи надад номоо бичихэд туслах уу? Миний номыг хамтарч дуусгаад чиний номыг эхэлье. Чи номоо яаж төгсгөх талаар бодож байсан уу?

- Бодож байсан, энэ талаар сайн юм огт бодохгүй л байна шүү - гэж Фродо баргар царайлан өгүүлэв.

- Юу гэсэн үг вэ найз минь! Ном сайхан төгсөх ёстой. Ийм төгсгөл байвал ямар вэ? Түүнээс хойш тэр хоёр дахин салсангүй, тэр хоёроос өөр жаргалтай хүн энэ орчлон дээр байсангүй.

- Гайхамшигтай гоё төгсгөл байна – гэж Фродо зөвшөөрөөд: - Гэхдээ би ийм төгсгөлд нэг их итгэхгүй л байна – гэж гунигтайхан хэлэв.

Хоббитууд эльфүүдийн оронд хэрхэн ирснээ ярилцаад дараа нь Мордор хүрэх замд ямар аюул тохиолдохыг таах гэж оролдов. Гэвч Уудам хөндийн сэтгэл амраах амгалан тайван байдал тэдний сэтгэлийн түгшүүрийг хөөлөө. Тэдний амьдралын баяр баясгалан аюултай аяны төгсгөл хүртэл сайхан байх болно гэсэн итгэл төрүүлж байлаа.

Хоббитууд найрсаг зочломтгой эльфүүдийн оронд өнгөрүүлсэн өдөр бүхэндээ баярлаж, хоол унд идэж уух бүрт, Ил галын тохилог танхимд сонссон дуу бүхэндээ баяр хөөр нь бялхан илэрч байв.

Өдөр хоног анзаарагдалгүй өнгөрсөөр намрыг өвөл залгалаа. Манант уулсаас үлээх салхин аажмаар хүйт дааж, навчис сэрчигнэн хийсч, тэнгэрийн гүн цэнхэр өнгө цайвартав.

Хоббитууд Уудам хөндийд хоёр сар амарч байтал арванхоёрдугаар сарын эхээр тагнуулчдын бүлгүүд эргэж ирцгээлээ. Тэдний зарим нь умард газар: Түргэн голын эх, Троллийн өндөрлөг, Андуин мөрний адаг хавийн уулсаар тандалт хийж, зарим нь Сирийн талын байдлыг шалгахаар Ширүүн гол, Саарал голоор уруудан Тарбадын балгаст хүрч, гурав дахь хэсэг нь Манант уулыг давж, Андуин мөрний дагуу Ирисийн хонхорт хүрч, дөрөв дэх хэсэг нь дорнод замаар яваад өмнө зүг болгоомжтой урагшилж, Балар шугуйн баруун зах хүрчээ. Хамгийн сүүлд Элрондын хөвгүүд ирэв. Тэд Андуин мөрнөөс зүүн тийш Бөглүүд тал, Хүрэн тал хүрсэн бөгөөд аяллынхаа талаар зөвхөн эцэгтээ л ярьжээ.

Тагнуулчид хар морьтнуудыг хаана ч харсангүй, тэдний тухай огт сонссон ч үгүй. Радагаст Карийн хүчирхэг холбоотон Агуу бүргэдүүд ч хар морьтны бараа хараагүй ажээ. Хорлум ч ор сураггүй алга болж, умард газарт сүрэг чонодолоохууд шиншилж явахыг тагнуулчид харсан байна. Ширүүн голд, Гарамын ойролцоо гурван хар морь, түүнээс доохно таван үхдэл, бас уранхай цувнууд олджээ.

- Ширүүн гол наанадаж найман сүг сүүдрийг живүүлжээ, сүг сүүдрүүд нэг хэсэгтээ хүч чадлаа алдаж, Мордорт хэлбэр дүрсгүй хий үзэгдэл болж очсон шиг байна. Хэрэв тэгсэн бол тэд мөддөө эргэж ирэхгүй учир бидний аялалд саад болохгүй. Дайсан олон зарцтай боловч биднийг хаашаа явсныг мэдэхийн тулд Уудам хөндийд нууцаар ирэх хэрэгтэй болно, учир нь дунаданчууд зүүрмэглэж суухгүй, энд ирээд бидний мөрийг хайх болно, бид мөр үлдээхгүйг хичээнэ. Гэвч алгуурлаж болохгүй, яг одоо л хөдлөх хэрэгтэй – гэж Гэндальф өгүүлэв.

Элронд хоббитуудыг өргөөндөө дуудлаа.

- Цаг боллоо. Бөгж хадгалагч замдаа гар. Гэхдээ замдаа тусламж авна гэж найдах хэрэггүй

гэдгийг санах хэрэгтэй. Бид хэтэрхий хол байна – гээд Элронд Фродог анхааралтай ширтэж: - Чи бодлоо өөрчлөөгүй биз? Бид чамайг албадах эрхгүй гэж нухацтай хэлэв.

- Үгүй ээ, би явна, Сэмтэй хамт- гэж Фродо баттай хэлэв.

- Би чамд зөвлөгөө ч өгч чадахгүй – Элронд хэсэг зуур дуугүй сууснаа өгүүлээд – Харанхуйн хөшиг өдрөөс өдөрт томорч байна, одоо бараг Саарал гол хүрчихсэн байна, харанхуйлсан газрыг би харж чадахгүй учраас Мордор хүртэлх чиний замыг урьдаас тааж чадахгүй. Чиний замд ил, далд олон дайсан тааралдана. Гэвч Сауроны эдлэн газарт ч гэсэн бөгж хадгалагч найз нартайгаа уулзана гэдгийг санаж яв. Бид чиний тухай мэдээг Мэргэдийн Зөвлөлийн бүх холбоотонд хүргэнэ, гэвч элч нар маань дайн болж байгаа газраар нэвтэрч гарна гэдэгт би бүрэн итгэлгүй байна.

Бид чамд найдвартай хэдэн дагуул гаргаж өгнө, гэвч чиний аяны амжилт нууц, хурд хоёроос хамаарах учир аль болох цөөхөн дагуул хэрэгтэй.

Та нар есөн хар морьтонтой тоогоор тэнцүү есөн хадгалагч явна. Чиний үнэнч Сэмээс гадна Гэндальф явна. Энэ бэрх аянаар түүний агуу их үйлс дүүрч ч магадгүй.

Бусад дагуулуудыг чинь Чөлөөт ертөнцийн чөлөөт ард түмэн болох эльфүүд, гномууд, хүмүүсээс гаргаж өгнө. Эльфүүдээс Леголас, гномуудаас Гимли, хүмүүсээс Арагорн явна гэсэн.

- Тэнэмэл үү? – гэж Фродо баярлан дуу алдахад:

- Тэр чинь – гэж Арагорн инээмсэглээд - Чи миний нийгэмлэгээс татгалзахгүй биз дээ?

- Би чамайг гондорчуудад туслахаар явна гэж бодсон учир надтай яваач гэж гуйх зориг хүрээгүй юм – гэж Фродо сэтгэл догдлон өгүүлэв.

- Явах нь ч явна аа, гэхдээ өмнөд газар хүртэл бид нэг л замаар явна, олон зуун лиг замыг бид хамтдаа туулна. Боромир бас явна, тэр туршлагатай аянч, эрэлхэг дайчин байгаа юм.

- Дахиад хоёр дагуул хэрэгтэй. Уудам хөндийд анчин олон шүү... гэж Элронд анхааруулав.

- Бид хоёр яах вэ? Бид хоёрыг авахгүй юм биз дээ? Бид хоёр ч бас Фродод бараа болж явмаар байна шүү! – гэж Пин сандрахад:

- Та нар ойлгохгүй байна, Мордор орох замд Фродог ямар их аюул тосч байгааг төсөөлөх ч үгүй байна.

- Фродо ч гэсэн эднээс илүү юм мэдэхгүй, бидний хэн ч гэсэн сайн мэдэхгүй. Ямар том сорилт тулгарч байгааг манай нөхөрсөг хоббитууд ойлговол энэ аялалд гарахыг хүсэхгүй байсан. Гэвч Фродогийн үнэнч андууд болохоор аянд гараагүйдээ дараа нь өөрсдийгөө гашуунаар зүхэх болно. Энэ аялалд эдний үнэнч нөхөрлөл хүч чадал, мэргэн ухаанаас хүчтэй. Агуу их ван Асалдар ч гэсэн Дайсантай халз тулалдаад дийлэхгүй, Зэвсгийн ууланд хүчээрээ гарч дөнгөхгүй гэдгийг чи надаас дутуугүй мэднэ – гэж Гэндальф санамсаргүй байтал

хоббитуудыг дэмжив.

- Чиний зөв - гэж Элронд дуртай дургүй зөвшөөрөөд – Гэвч Хоббитанд ч аюул нүүрлэж байна, манай хоббитууд энэ тухай нутгийнхандаа хэл хүргэх хэрэгтэй гэж би бодсон юм. Ямар ч гэсэн Ногоон Молтогчин ийм аялалд гарахад хэтэрхий залуу байна. Би түүнийг Мордор руу явуулж чадахгүй.

- Тэгвэл намайг хорь гэж тушаа, тэгэхгүй бол би тэртэй тэргүй оргоно – гэж Пин хэлэхэд Элронд түүн рүү харж байснаа санаа алдаж:

- Яая гэхэв, чамайг ч гэсэн явуулахаас – гэж гунигтай инээмсэглээд – За ингээд бөгж хадгалагчдын баг бүрдлээ. Долоо хоногийн дараа замдаа гар- гэв.

Эльф дархчууд Нарсил илдийг дахин давтаж, мөрөн дээр нь хавирган сар, нар хоёрын хооронд долоон од цохисон нь Нуменорын хаадын шууд удам Арагорны хүү Арагорн Гондорын вант улсыг хамгаалахаар мордлоо гэсэн утга агуулжээ. Шинэчлэн давтсан илд нэн сүрлэг харагдах бөгөөд өдөр хар хуйнаас нь сугалахад наранд улайссан мэт гялалзаж, шөнө сарны хүйтэн гэрэлд мөсний өнгөөр бүдэгхэн туяарна. Арагорн илдэндээ Андрил буюу дахин төрсөн цахилгаан гэдэг шинэ нэр өгөв.

Арагорн, Гэндальф хоёр замд гарах бэлтгэлээ базааж, аль дивангарын үеэс Элрондын цайзад хадгалагдаж ирсэн эртний Дундад газрын зургийг судлав. Заримдаа Фродо тэр хоёртой хамт суувч ихэнх цагаа Бильботой ярилцаж өнгөрөөв.

Орой нь хоббитууд бүгдээрээ цугларч Ил галын танхимд суугаад эльфүүдийн эртний домог сонсч, өдөр нь Мерри, Пин зүүрмэглэж буй өвлийн цэцэрлэгээр зугаалан Фродо, Сэм хоёр Бильбогийн өрөөнд сууж, түүний шүлэг болон дуусаагүй номынх нь хэсгээс сонсч байлаа.

Арванхоёрдугаар сарын өдөр зэврүүн хүйтэн байлаа. Цэцэрлэгийн нүцгэн моддын мөчир дорнын салхинд гулзайж, алсад, хөндийн хойт уулын бэлийн нарсан ой уйтгартай шуугиж байв. Газарт наалдах шахсан тэнгэрээр тугалга мэт хүнд хар үүлс нүсэр биеэ дааж ядан мөлхөх мэт нүүнэ.

Бөгж хадгалагчид өглөөгүүр хөдлөх байсан боловч Элронд тэдэнд үдэш гараад шөнийн харанхуйгаар халхавчлан Уудам хөндийгөөс холдохыг зөвлөв.

- Саурон олон нүд чихтэй. Хоёр хөлтнүүд ч байгаа, дөрвөн хөлтнүүд ч байгаа, далавчтай нь ч байгаа. Сүг сүүдрүүд өдийд эзэн дээрээ эргэж очсон байгаа, тиймээс тэр ялагдсандаа хорсч, хордсондоо байж ядаж байгаа. Умар зүг рүү тагнуулуудаа явуулсан нь мэдээж. Шувууд хурдан нисдэг учир өдрийн гэгээ, цэлмэг тэнгэрээс болгоомжилж яваарай!

Бөгж хадгалагчид аян замд зөвхөн хөнгөн зэвсэг авсан бөгөөд тэдний гол зэвсэг нь нууц байдал байв. Бөглүүд ойн хэсүүлч Арагорны гандмал бор ногоон цувны дотуур сэргэн шинэдсэн Андрил илд зүүлттэй байх бөгөөд тэр өөр зэвсэг авсангүй. Боромир Андрилтай ижилхэн боловч түүнтэй адил үе дамжин алдаршаагүй Нуменорын илд, хөнгөн бамбай, эвэр бүрээгээ агсчээ. Тэрбээр бүрээгээ нэгэнтээ үлээхэд чимээгүй хөндийн дээгүүр өтгөн баргил

дуугаар хүнгэнэн цуурайлж, алсын хүрхрээний нүргээн, хадан эргийнхээ дундуур хүржигнэн урсах мөрний чимээ, нүцгэн мөчрүүдийг ганхуулсан салхины исгэрээнийг дарж байлаа.

- Хараалт Сауроны хар зарц нар сарнин бутраг! – хэмээн гондор баатар бүрээгээ буулгангаа өгүүлэв.

- Одоо бүрээгээ далдал даа, Боромир минь. Мөддөө үлээх хэрэг гарахгүй биз – гэж Элронд түүнд жинтэй хэлээд – Яагаад гэдгийг чи ч өөрөө мэдэж байгаа биз дээ? – гэхэд:

- Мэдээж – гэж Боромир хариулаад – замдаа би тагнуулуудаас нуугдахаа мэдэж байна. Гэвч эрэлхэг дайчны хувьд би аян замдаа хулгайч шиг нуугдан гарч чадахгүй байна – гэв.

Хадгалагчдын отрядад ганцхан Гимли л хөө хуягаа ил өмсч, бүсэндээ байлдааны сүх хавчуулжээ. Леголас нум сум, урт кинжаалаар зэвсэглэж, Фродо нууц зэвсгийнхээ талаар нөхдөдөө үг цухуйлгахгүй байхаар шийдсэн ба нөгөө гурван хоббит Булшнаас олзолсон илдээ агсчээ. Гэндалф шидэт очир болон эльфүүдийн давтсан Яррист илдээ агсав.

Элронд түүнд дулаан хувцас – үстэй хүрэм, цув, солих хувцас, хүнс, хөнжил бэлтгэж өгснийг тэд Уулын суурингаас авч гарсан хөгшин понийн нуруун дээр ачив.

Гэвч одоо тэр адгуусыг танихын арга байсангүй. Лав арван таван насаар залуужсан мэт харагдана. Сэм хөгшин найзаа заавал авч явна, Билл /тэд түүнийг ингэж нэрлэжээ/ энд үлдвэл нүд анина гэж зүтгэсэн юм байж.

- Энэ бол гайхам ухаантай амьтан. Энд хоёр сар байсан бол шууд ярьж эхлэх байсан. Тэр надад үгээр яриагүй ч гэсэн энд үлдээдэг л юм бол та нарын хойноос оргоод очно гэж Пинээс илүү ойлгомжтой тайлбарласан – гэж Сэм зүтгэжээ.

Үнэн хэрэгтээ Билл ачаандаа дарагдсан боловч хөнгөн ачаатай мөртөө хүнд сэтгэгдэлтэй гарч байгаа бусад аянчдыг бодвол их л сэтгэл хангалуун байгаагаас нь харвал Сэмийн үг ортой бололтой.

Эльфүүдтэй Ил галын танхимд салах ёс хийв. Хадгалагчид ордны зүүн талын хаалган дээр гарч, түр саатсан Гэндалфыг хүлээв. Дорно зүгээс харанхуй хүйтэн уур амьсгал үлээж, ил галын дулаахан гэрэл шилтгээний цонхыг гэрэлтүүлж байв. Бильбо жихүүцсэн байртай цуваа нөмрөөд Фродогийн хажууд чимээгүй зогсоно. Арагорн үүдний довжооны гишгүүр дээрх толгой унжуулан суух агаад энэ аймшиггүй аянчийн толгойд ямар бодол эргэлдэж буйг ганцхан Элронд л таамаглаж байлаа. Сэм Биллийн духыг маажингаа Бруинен мөрний ширүүн урсгал цовхчин байгаа өндөр эргийн зүг хэнэггүй ширтэж байв.

Замд гарахын өмнөх өдрийн өглөө Фродо ганцаараа Бильбогийн өрөөнд ороход цаадах нь хаалгаа сайн хаагаад орон доогуураасаа модон хайрцаг гаргаж ирээд тагийг нь нээж, ихэд элэгдсэн ширэн хуйтай илд гаргаж ирэв.

- Чиний илд хугарсан, би үүнийг дахин давтуулах санаатай хадгалж байсан юм. Цагт нь давтуулсангүй, одоо оройтсон, Уудам хөндийн хамгийн гарамгай дархан ч нэг өдрийн дотор

илд давгаж амжихгүй. Тэгэхээр энэ илд чамд тохирох юм биш биз? – гэж Бильбо хэлээд илдийг хуйнаас нь сугалахад гайхалтай уран өнгөлсөн ир нь өрөөг хүйтэн өнгөөр туяаруулав. – Энэ илд намайг олон удаа үхлээс аварч байсан юм. Харин одоо надад гэхээсээ чамд илүү хэрэгтэй – гэхэд Фродо ихэд талархан илдийг хоёр гардаж авлаа.

- Чамд өөр бас нэг бэлэг өгөхийг хүсч байна -гээд Бильбо хайрцагнаасаа жижигхэн боловч нэлээн жинтэй бололтой нэгэн боодолтой юм гаргав. Даавуун боодлыг нямбайлан задлахад бүдэг мөнгөлөг өнгөөр гялалзсан цагаригнуудаар сүлжсэн хөө хуяг байхыг Фродо харлаа. Нарийн мөртөө бат бэх, их нягт тэр хуягийг усан болороор чимж, бүсэн дээр нь гэрэлт сувд солонгорон байв.

- Гоё эд байгаа биз? – гэж Бильбо хөө хуягийг цонхонд ойртуулан хараад – Тун ч хэрэгтэй эд дээ, эргэлзэх хэрэггүй. Нэгэн цагт үүнийг надад Торин бэлэглэж байсан юм, одоо надад аяллын маань дурсамж л болно уу гэхээс ямар хэрэг болоо аж. Гарт барьж байхад хүнд байдаг мөртөө өмсчихөөр огт жингүй юм шиг болдог юм.

- За би... юу л даа..., дотор талыг нь хардаг юм билүү... жаахан эвгүй санагдаад байна, - гэж Фродо хэлэхэд:

- Анх удаа харж байхад надад ч гэсэн тэгж санагдаж байсан юм. Зүгээр л хувцсан дотуураа өмсчих, тэгээд л болох нь тэр. Хэн ч мэдэхгүй. Харин хэнд ч бүү хэлээрэй, бүү үзүүлээрэй! Үүнийг... – гээд Бильбо эргэн тойрноо харснаа Фродо руу тонгойж: - ... ямар ч зэвсэг, тэр ч байтугай Хар морьтны илд ч нэвглэхгүй гэж би найдаж байна – хэмээн шивнэж хэлэв.

- Тэгвэл би авлаа – гээд Фродо Бильбогийн зөвлөсний дагуу хуягийг хүрмэн дотуураа өмсөөд, дээр нь цуваа өмсөхөд хуяг байтугай илд нь үзэгдэхгүй болов.

- Чи найдвартай хамгаалагдсан, зэвсэглэсэн гэж хэн ч таамаглахгүй. Аян замдаа сайн явахыг ерөөх л үлдэв шив дээ... – гээд тэр цонх руу эргэж, ямар нэг хөгжилтэй дуу аялав.

Гэвч энэ арга нь Фродог хуурч чадсангүй. Бильбо нутаг нэгтнүүдээсээ, хамгийн дотно хүнээсээ салах их хэцүү байгааг Фродо харлаа.

- Би чамд яаж талархахаа мэдэхгүй байна...

- Тэр яахав - гэж Бильбо хэлээд мөрөн дээр нь нөхөрсгөөр алгадсанаа – Энэ чинь ёстой мөр мөн дөө! – гээд хөө хуяганд өвтгөсөн хуруугаа сэгсэрч: - Хоббитууд бие биедээ туслах ёстой. Тэгээд чи бид хоёр чинь ах дүүс. Тэгэхээр надад талархал илэрхийлэх хэрэггүй... Харин аян замд болгоомжтой, ухаалаг байж, харь газрын ард түмнүүдийн домог түүхийг тогтоож авна гэж надад амла, би номоо дуусгахыг хичээе. Магадгүй, чиний аян замын адал явдлыг бичих цаг олдох ч юм билүү хэн мэдлээ – гээд дуугүй болж, цонх руу очоод хагас хоолойгоор ийн дуулав:.

Гадаа нар гийнэм,

Гэрт гал бадарнам.

Зун дэлбээлж намар хагдрах

Зул цэцэг мэт хийсч одсон

Гэгээн зуны өдрүүдээ

Гэгэлзэж би сананам.

Гадаа салхи сэвэлзэхүйд

Газраар навчис хөглөрөхүйд

Аалзны тор мэт сэтгэл минь

Агшин зуурт хоосорном...

Өнгөрсөн өдрүүдээ дурснам,

Өнө холыг дууднам,

Ээлж нь болоод өвөл ирэхүй

Элээсэн амьдралын мөрийг,

Эхлээд дуусгаагүй ажлыг,

Эхний цас балланам.

Их ертөнц үүдээ дэлгэж,

Ирээдүйн хүмүүсийг уринам.

Өнгөрсөн өдрүүдээ дурсаж,

Өөрөө би энд зогсовч

Эргэж ирэх андуудаа

Угтаж золгох найдвэр тээж,

Өр зүрх минь гадаа байнам.

- Билл, найз минь дээ, чи бидэнтэй дэмий л явж байгаа юм даа. Эндээ үлдээд, зовлон бэрхийг үл амсан... уудам хөндийн амтат өвсийг зажилж зогсох байсан юм... тэгээд хавар болно... – хэмээн үглэв. Гэвч Билл түүнд юу ч хэлсэнгүй.

Сэм үүргэвчээ засангаа хэрэгтэй бүхнээ авсан эсэхээ санаж дотроо бүртгэв. Хоол ундны сав суулга, (Мэргэд энэ тухай боддоггүй юм), лаазтай давс (хэн ч энэ тухай санахгүй), хоббитан тамхи (ээ, бага л байна даа!), хэдэн хос ноосон оймс (гол нь хөл дулаан байх хэрэгтэй) Фродо мартаж, Сэм нямбайлан цуглуулсан бусад жижиг зүйлс (гэнэт хэрэг болоход нь их л додигор гаргаж өгнө). Бүгдийг авсан шиг байна...

- Олс авсан уу? – гэж гэнэт санав – Ээ маанаг, олс авсангүй! Өчигдөр орой би өөртөө: “Сэм, олс аргамж заавал ав, магад хэрэг болно!” гэж хэлж байсан даа. Одоо яая гэхэв, олсгүй л явахаас. Одоо хаанаас олох вэ?

Төдөлгүй Гэндальф гарч ирэв, Уудам хөндийн эзэн даган гарч ирлээ.

- Өнөөдөр бөгж хадгалагч аян замд гарч байна – гэж Элронд нам дуугаар үгээ эхлээд: Галт ууланд хүрэх аялал эхэллээ. Миний үдэлтийн үгийг сонсоцгооно уу. Хадгалагчид бөгжний хувь заяаг хариуцаж, түүнийг замдаа гээхгүй, Дайсны зарц нарт өгөхгүй гэсэн бэрх үүргийг сайн дураараа хүлээсэн юм. Тэр бөгжийг Мэргэдийн зөвлөлийн мэргэнд юм уу өөр хадгалагчид түр өгөх эрхтэй, гэхдээ зөвхөн зайлшгүй онцгой тохиолдолд. Хадгалагчид андгай тангаргаар холбогдоогүй байна. Учир нь замд юу тохиолдохыг, зорьсон газраа хүрч чадах эсэхийг хэн ч мэдэхгүй. Мордорт ойртох тусам аюул ихэсч, та нар буцахад бэрх болно гэдгийг санаж яваарай. Тиймээс...

- Сорилтоос зугтаж ухарсан хүнийг урвагч гэж үзнэ - гэж Гимли түүний үгийг таслав.

- Өөрийн хүчээ сорьж үзэлгүй тангараг өргөөд дараа нь тангаргаасаа няцвал тангаргийн дайсан болно. Тиймээс хөнгөн хуумгайгаар тангараг өргөснөөс өргөхгүй байсан нь дээр – гэж Элронд хэлэв.

- Тангараг хүчгүй хүнийг хүчтэй болгоно...

- Бас нугалж ч болно – гэж Элронд хэлээд – Бүхнийг урьдаас таах хэрэггүй. Хөдөлцгөө дөө, бидний талархсан сэтгэл та нарыг хамгаалах болтугай! Замыг тань одод тодоор гэрэлтүүлэх болтугай!

- Сайн яваарай... аян зам тань өлзийтэй байх болтугай! – гэж Бильбо сэтгэл догдолсондоо түгдрэн байж хэлээд - Чи замдаа тэмдэглэл хөтөлж чадахгүй байх... Фродо, найз минь... эргэж ирээд... чамайг эргэж ирнэ гэж би итгэж байна... надад адал явдлаа яриарай, би номоо заавал дуусгана... Хурдан ирээрэй! Баяртай!

Уудам хөндийн олон албатууд хадгалагчдыг үдэв. Замдаа сайн явахыг ерөөсөн эльфүүдийн уянгалаг хоолой дуурсч байсан боловч хэн ч инээсэнгүй, дуу дуулсангүй - үдэлт гунигтайхан болов.

Аянчид Бруинен голын гүүрээр гарч, эльфүүдийн эртнээс амьдарч ирсэн уудам хөндийн дундуурх өндөрлөг өөд өгсөв. Тэд өндөрлөг дээр гараад эргэн харж, сүүлчийн гэгээн орон болсон Уудам хөндийн шилтгээний гал гэрлийг сүүлчийн удаа халиагаад шөнийн харанхуйд уусан одов.

Хадгалагчид Их замаар Гарам хүрээд өмнө зүг рүү огцом эргэлээ. Тэдний өмнө зүүн талаас Манант уулаар зааглагдаж, гуу жалга, бутлаг ургамлаар дүүрэн, чулуурхаг тал цэлийж байв. Тэд уул давж, Андуин мөрний хөндий рүү орсон бол өмнөд газарт хурдан хүрэх байв. Их мөрний хөндий үржил шимт газар, сайн замаараа алдаршсан билээ. Тиймээс Сауроны тагнуулууд тэр хавийн газрыг хяналтдаа авсан нь мэдээж тул аянчид Манант уулаар Андуинаас алслагдсан баруун талаар өмнө зүг рүү явсан нь аюул багатай гэж тооцоолсон байв.

Цувааг Саарал Гэндалф тэргүүлж, баруун гарт нь энэ хавийн газрыг арван хуруу шигээ мэддэг Арагорн явж, бусад нь араас нь цувран хамгийн сүүлд шөнө өдрөөс илүү хардаг эльф Леголас явна. Эхэн үед зам зүдэргээтэй байсан тул Фродо дорнын хүйтэн салхинаас өөр бараг юу ч тогтоож харсангүй. Энэ салхи Манант уулын зүгээс үлээж буй учир ясанд хүртэл нэвтрэм чийглэг байсан тул Фродо дулаан хувцастай ч гэсэн өдөр шөнөгүй даарч явлаа.

Өглөө болоход аянчид амрах газар олж, өргөст бугаар дүүрэн хонхорт буув. Орой нь ээлжийн харуул тэднийг сэрээж, оройн хоолоо идээд нойрмоглож, даарсан амьтад замаа үргэлжлүүлээ.

Хоббитууд ийм аялалд дасаагүй тул өглөө үүрээр босоход ядарсандаа хөл нь гуйвж, хичнээн явсан ч газар хороохгүй, өдөржин шөнөжин нэг л байрандаа дэвслээд байгаа юм шиг санагдана. Хэдэн зуун лиг явсан ч нэг л янзын гуу жалга, өргөст бугаар дүүрэн тэгш тал үргэлжилнэ. Гэвч уулс улам л ойртсоор байв. Манант нуруу баруун тийш хөндөлдөж, одоо тэд харанхуй хавцал, эгц хадан цохионууд бүхий уулын бэлээр явж байлаа. Аль эрт орхигдсон, муруйж тахирласан жимүүд аянчдыг байн байн мухардалд оруулж, нэг бол ширүүн урсгалт голын эгц эрэг, нэг бол өргөн гүн хонхор, эсвэл ёроолгүй мэт налуу эрэгт тулж байв.

Арван дөрөв дэх шөнө цаг агаар өөрчлөгдөв. Дорнын салхи түр намжсанаа хойт зүгээс тасралтгүй үлээж, үүрээр хүнд үүлс замхран, агаар тунгалаг бөгөөд улам хүйтэн болж, Манант нурууны дээгүүр аварга том нар мандсан ч хүйтний эрч саарсангүй. Аянчид эрт цагт боржин хадаар сийлсэн мэт хар саарал өнгөт аварга царс модтой толгодод хүрэв.

Өмнө талд аянчдын замыг хааж мөнгөрөн харагдах мөнх цаст гурван оргилтой аварга том нуруу хөндөлсчээ. Фродо тэр уулсыг анхааралтай ажиглан зогсч байтал Гэндалф дэргэд нь чимээгүйхэн алхалж ирээд, алсын цаст оргилыг саравчлан харав.

- Тэндээс Остранны буюу хүмүүсийн нэрлэдгээр Царстын орон эхэлдэг юм. Остраннд нэг үе эльфүүд амьдардаг байсан, гэвч тэр цаг аль эрт улиран оджээ. Уудам хөндийгөөс Остранн руу ниссэн шувуу ердөө дөчин таван лиг нисэх ёстой. Харин явгаар явах юм бол хоёр гурван зуун лиг зам туулна. Тэндхийн уур амьсгал дажгүй сайхан, газар нь ч умард газрыг бодвол үржил шим сайтай, гэвч бид одоо хоёр дахин өндөр сонор сэрэмжтэй явах хэрэгтэй, дайсан ийшээ тагнуулуудаа илгээсэн нь лавтай – гэж тэр хэлэв.

- Жинхэнэ нартай сайхан ганц өдрийн төлөө би сонор сэрэмжээ арав дахин дээшлүүлэхэд ч бэлэн байна! - гэж Фродо юүдэнгээ буулгангаа өчив.

- Уул урд талд гарчихаж - гэж Пин – тэдний ярианд үг хавчуулаад – урд шөнө бид дорно зүг

рүү эргэчихсэн бололтой гэв.

- Үгүй дээ, нартай цэлмэг өдөр холын юм харагддаг болохоор л чи тэр уулыг харж байна. Манант нуруу Остранны хилээс аажмаар баруун өмнө зүг рүү эргэдэг юм. Биднийг Уудам хөндийн эзнийд байхад чи газрын зураг руу нэг ч удаа хараагүй юм аа даа?

- Яалаа гэж харахгүй байх билээ? Би харах нь байтугай судалсан гэж хэлсэн ч болно. Гэвч миний харааны ой муу. Харин манай Фродо бүгдийг санаж байгаа байх!

- Бидэнд ямар ч газрын зураг хэрэггүй – гэж хоббитуудын дэргэд ирсэн Гимли өгүүлэв. Тэр алсын уулсыг сэтгэл догдолсон байртай харж – Энэ чинь миний өвөг дээдсийн нутаг шүү дээ. Тэ-эр харагдаж байгаа чинь үлгэр домогт мөнхөрсөн мөнх цаст Зирак, Бараз, Шатхур!

Би тэр оргилуудыг ганцхан удаа, бүр холоос харсан боловч надад их танил байна. Тэдний тухай олон домог байдаг, манай урчууд дүрийг металл, чулуун дээр нэг бус удаа дүрсэлж байсан. Яагаад гэвэл тэдний доор, асар том агуйд эртний гномуудын эзэнт улс Казад-Дум, эльфийн хэлээр Мори, нийтийн хэлээр бол Ёроолгүй хар гэдэг юм. Арай цаахна Баразинбар оргил сүндэрлэж байна - эльфээр Карадрас буюу Хүрэн эвэр; түүний цаана, арай баруунтаах хоёр оргил бол Зиракзигил – Селебдо буюу Мөнгөлөг, Бундушатхур – Фануиндхол буюу Бүдэг оргилууд.

Давшгүй манант уул энд нарийсан гүдийж, даваа үүсгэсэн, түүгээр даваад Дундад газрын бүх гном анддаггүй хөндий рүү орж болно. Тэр хөндийг гномын хэлээр Азанулбизар, эльфээр Нандурион, нийтийн хэлээр – Харголын хөндий гэдэг юм.

- Бид Азанулбизарт очих хэрэгтэй, Хүрэн хаалгын даваагаар давж, Хар голын хөндий рүү орно. Тэнд Толин нуур, түүнээс эх авсан Мөнгөн голыг үзнэ – гэж Гэндалф хэлэв.

- Толин нуурын усыг хараад ханашгүй, Кибель-Налын булаг шиг хүйтэн. Эцэг өвгөдийнхөө дархан нуурыг үзэх завшаан надад тохиосон гэж үү?

- Хэрэв үзэх завшаан тохиовол дөнгөж хажуугаар нь гарна найз минь - гэж Гэндалф гномд хэлээд. – Бидний зам Толин нуурын хажуугаар гарч, Мөнгөн голоор уруудаад Таимын шугуйг гатлаад Их мөрөнд хүрнэ, дараа нь... –гээд тэр дуугүй болов.

- Дараа нь яах вэ? –гэж Мерри хэлэв.

- Дараа нь цаашаа явна даа, аяллынхаа эцэст хүртэл явна... эцсийн эцэст хүртэл. Хойшид юу болохыг яагаа ч үгүй байхад таагаад яахав. Остранна хүртэл яваад ирлээ. Энэ бол ялалтад хүрэх эхний алхам. Энд ганц нэг хоног амарна. Остранна эмчилгээний уур амьсгалаараа алдартай, бид хүчээ сэлбэхэд илүүдэхгүй. Нэгэн цагт эльфүүдийн амьдарч байсан энэ хязгаар анагаах уддисаа ер бусын урт хугацаанд хадгалж байгаа юм.

- Зүйтэй - хэмээн Леголас Гэндалфыг дэмжээд – гэвч ойн уугуул иргэд бидний хувьд Остранны эльфүүд нэг л сонин ард түмэн шиг санагддаг байсан, одоо би энд тэдний ул мөрийг ч харахгүй байна. Мод, бут, өвс ногоо чив чимээгүй байна. Гэвч байзаарай... – гээд

Леголас нэгэн мөч нам жим зогссоноо - ... тийм байна, хад чулуу тэднийг санаж байна. Сонсч байна уу? Та нар чулуунуудын гомдлыг сонсч байна уу? “Тэд биднийг хамгаалж байсан, биднийг үүрд үлдээсэн, бидэнд амь оруулаад өөрсдөө үүрд явчихсан. Тэд үүрд явчихсан, мөнхийн буудлаа олчихсон” – гэж байна.

Гэвч аянчид зөвхөн салхины исгэрэх чимээг л сонсч байв. Царсан ойгоор хүрээлэгдсэн хонхорт ороод аянчид багахан гал асааж, амттайхан хоол ахиухан хийж идэв. Тэд унтах гэж яарсангүй, бүтэн нэг өдөр амарна, дараа нь бас нэг урт шөнө тайван унтаж амарна. Дараа нь дахиад нэг амгалан тайван өдөр байна. Ганцхан Арагорн л тайван биш байлаа. Хоолны дараа тэр өндөр толгой дээр гараад алсын уулсыг удаан ширтэж, ямар нэг чимээг ихэд хичээнгүйлэн сонсч байв. Тэгснээ буцаж ирээд санаа амар, хөгжилтэй сууцгааж байгаа аянчдыг мэл гайхсан шинжтэй харав.

- Юу болоов, Тэнэмэл ээ? - Чамд ямар нэг юм дутуу байна уу? Эсвэл дорнын салхиа санаа юу? – гэж Мерри асуухад:

- Одоохондоо үгүй - хэмээн Арагорн мушийн инээх аядаад – Гэвч үнэндээ ямар нэг юм дутаад байна. Би энэ газарт өвөл ч ирж байсан, зун ч ирж байсан. Тэнд оршин суугчид байхгүй болохоор анчид байхгүй, тиймээс элдэв шувууд, гэм хоргүй жижиг амьтад зөндөө байсан юм. Гэтэл одоо тэд бүгдээрээ сөнөчихсөн юм шиг нам гүм. Олон бээр газарт нэг ч амьд амьтан байхгүйг би мэдрээд байна. Тэгээд ямар учраас гэдгийг мэдмээр байна.

- Энэ ч үнэхээр ойлгомжгүй байна шүү. Арай бид нар бүх амьтдыг айлгачихаагүй байлтай – гэж Гэндалф гайхав.

- Бид ан хийгээгүй. Остраннд явж байхад би ямагт амгалан тайван байсан. Гэтэл одоо байнга сэтгэл түгшээд байх юм – гэж Арагорн хэлэв.

- Тэгэхлээр бид бэлэн юунд ч бэлэн байх хэрэгтэй. Хэрэв бидэнтэй мөрч, тэгэхдээ зүгээр нэг мөрч биш Арагорн өөрийн биеэр хамт явж байгаа бол түүний мэдрэмжид итгэх ёстой. Чимээгүй бай андууд минь, одоо харуулаа гаргая – гэж Гэндалф хэлэв.

Тэр өдрийн анхны харуулд Сэм гарлаа. Бусад нь бүгд тайван унтаж, ганц Арагорн унтах бодолгүй байгаа харагдана. Аянчид яриагаа зогсоож, унтмагц нэг л хүнд түгшүүрийн нам гүм болж, үүнийг Сэм биеэрээ мэдэрч байв. Унтаж байгаа хүмүүсийн амьсгаа тов тод дуулдаж, пони морь хөлөө сэлгэхэд ер бусын чанга төвөргөөн сонсдон, өөрийнх нь үе мөч дуугарч байгааг ч Сэм сонсч байлаа. Тэнгэрт бүртийх ч үүлгүй, нар их л удаанаар дээш хөөрөн, үхмэл нам гүм улам л гүнзгийрч байв. Дараа нь өмнө зүгт, үүлгүй тэнгэрт нэг хар цэг тодорч, улам л наашилж байх нь үзэгдэв.

- Энэ юу вэ? Үүлтэй адилгүй л юм байна даа – гэж Сэм Арагорнд шивнэв. Арагорн хариу хэлсэнгүй, тэнгэр өөд харсаар байв. Төдхөн нөгөө хар толбо томрон наашилсаар тус тусдаа олон хар цэгүүд боллоо.

- Энэ чинь шувууд байна шүү дээ! - хэмээн Сэм аяархан дуу алдлаа. Шувууд ер бусын доогуур, эгц урагшаа нисэх мөртөө газраас ямар нэг юм хайх мэт таруу эгнээгээр аажуухан урагшилж

байв.

- Хэвг, чимээгүй бай! - гэж Арагорн шивнээд, Сэмийг бутан доогуур чихэв. Хэдэн зуун шувуу үндсэн сүргээсээ тасарч, аянчдын амарч байгаа хонхрыг чиглэн маш хурдан нислээ. Тэр шувууд хэрээтэй адил боловч маш том, тас хар байсан бөгөөд хонхор дээгүүр нисэн өнгөрөхөд сүүдэр нь нарыг хором зуурт халхалж, чангаар гуаглах, далавчнуудын сүр сархийн дэвэх чимээ нам гүмийг эвдэв.

Шувууд нисч өнгөрмөгц Арагорн босч, Гэндальфыг сэрээлээ.

- Баруун талын дээгүүр олон сүрэг хар хэрээ нисч өнгөрлөө, нэг сүрэг нь дөнгөж сая бидний дээгүүр гарлаа. Остраннд хар хэрээ байдаггүй, тэд Сирийн өндөрлөг талд үүрээ засдаг юм. Яах гэж наашаа ирснийг бүү мэд, зүгээр л идэш хайж яваа ч байж мэдэх юм, гэхдээ тэднийг Дайсан нааш нь тагнуулаар явуулсан гэж би бодож байна. Их өндөрт элээнүүд эргэлдэж байна, тэд ч лав Сауроны зарц нар байх. Бид одоо эндээс зайлах хэрэгтэй гэж бодож байна. Остраннд дайсны тагнуулууд дүүрчихлээ.

- Тийм тохиолдолд тагнуулууд Хүрэн хаалгыг манана, тэгэхлээр даваа өөд явж болохгүй. Бид яаж Хар гол хүрэх нь сонин байна аа даа? За яахав, энэ тухай дараа бодъё. Одоо хамгийн гол нь Манант уул хүрэх хэрэгтэй. Чиний зөв, бид өнөөдөр хөдлөх хэрэгтэй, юун амрахтай манатай юм боллоо.

- Аз болоход бид бага гал түлсэн учир хэрээнүүд ирэхээс өмнө унтарсан. Галтай удаан хугацаагаар салах ёс хийх болох нь дээ.

- Ямар хачин шийтгэл гээч вэ, тайван унтаж хонохгүй, олон хоног галын бараа харахгүй - гэж Пин юу болсон тухай сонсоод үглэж – муусайн хар хэрээнүүдээс болоод бид унтаж ч болохгүй нь ээ, би бүр халуун хоол иднэ гэж бодож байсан юмсан!

- Мөрөөд мөрөөд, жишээ нь би нэг сайхан дулаацаж, гаанс тамхи тайванхан татна гэж мөрөөдөж байлаа. Гэвч нэг зүйлийг хатуу амлая, өмнөд газарт очоод бид заавал дулаацна – гэж Гэндальф хэлэв.

- Дулаахан байтугай халуухан болох вий гэхээс л айж байна. Гэсэн ч бид ямар ч гэсэн Галт уул хүрнэ, гэртээ ч харина. Хүрэн хаалга гэхээр нь би нөгөө галт уул нь юм байх гэж бодсон шүү. За яахав, бид тэр Галт ууланд нь хүрэхдээ л хүрнэ, гэртээ ч харина. Хүрэн хаалга гэхээр нь тэр уул нь мөн юм байх бодсоныг яана. Гимли өөрийнхөө хэлээр жинхэнэ нэрийг нь хэлэхээр л мэдлээ - Бариза... Бирази... Дайсан хүртэл хэлээ хугалчихмаар юм!.. товчхондоо бид тэнд хүрэх болоогүй юм байна – гэж Сэм үглэв. Тэр газрын зурагт итгэдэггүй, зураг харахаар эндхийн зай бүхэн асар их юм шиг санагдаад бүр будилж гүйцжээ.

Өдөр нь хадгалагчид хонхорт нуугдав. Хэрээнүүд хэд хэдэн удаа эргэж ирсэн боловч тэднийг хараагүй бололтой орой гэхэд оргүй алга болжээ. Хэсэг хүлээсний дараа аянчид хоолоо идээд мөрөө баллаж, жаргах нарны туяанд гялалзан байгаа Баразинбар уулыг чиглэн өмнө зүг хөдөллөө. Уулын бэлийн өндөрлөгт харанхуй болж, тэнгэрт одод дараа дараагаараа гялалзав.

Арагорн тэднийг нэгэн зөрөг дээр гаргалаа. Зөрөг ч гэж дээ, эрт дээр үед орхигдсон их хөлийн зам бололтой. Энэ зам Остранныг уулын даваатай холбодог байсан нь илт. Уулын цаанаас тэргэл сар мандаж, түүний мөнгөлөг хөхөвтөр гэрэлд замын хоёр талын цохионууд хар сүүдрээ газарт унагана. Фродо цохионуудыг анхааралтай хараад тэд бол цохионууд биш, хадан ууланд урласан хөшөөнүүд болохыг мэдэв. Цагийн салхи тэднийг нураажээ.

Аянчид шөнөжин өмнө зүгийг барин урагшлав. Фродо санамсаргүй тэнгэр өөд хартал тэдний дээгүүр чимээгүй сүүдэр гялсхийн өнгөрч, оддын хөгжилтэй гялбааг нүд ирмэх зуурт халхлахыг бараг үзэх биш, бүүр түүр мэдрэв.

- Чи сая тэнгэрт юу ч ажигласангүй юу? – гэж Арагорнтой зэрэгцэн урд нь алхаж яваа Гэндальфаас сэмхэн шивнэж асуув.

- Ажигласан ч үгүй ээ, харин мэдэрсэн гэж Гэндальф хариулаад – хоромхон зуурт тэнгэр харанхуйлах шиг санагдсан. Бидний дээгүүр үүл нүүсэн байлгүй.

- Тун ч их хурдан нүүлээ дээ – хэмээн Арагорн хэнд ч үл хандан бувтнаад – Ялангуяа огт салхигүй байхад шүү...

Өөр гойд юм тохиолдсонгүй. Нарлаг, тунгалаг өглөө болсон ч дорноос дахиад л сэрүүн салхи үлээв.

Тэд дахиад хоёр шөнө Манант уул руу алхаж, муруй тахир зам нэг толгод өөд өгсч, нэг хонхор хотгор руу орсоор аажмаар дээш өгсч байгаа нь анзаарагдамгүй байв. Хоёр дахь шөнө төгсөхөд аянчид Баразинбарт тулж очлоо. Тэр бол мөнх цасан оргилтой, ой мод ч үгүй, өвс ургамал ч үгүй хүрэн хадан хясаатай оргил байлаа.

Бүрхэг, хүйтэн өглөө болж, саарал үүлс нарыг хаан, зүүн хойноос зэврүүн салхи үлээв. Гэндальф салхины өөдөөс харж үнэрлээд, Арагорнд:

- Өвөл биднийг гүйцлээ дээ. Хойт уулс бараг бэлдээ хүртэл цастай байна. Нөгөөдөр бид Хүрэн хаалга өөд өгсөнө. Тэнд биднийг тагнуулууд харчихаж магадгүй, гэхдээ хамгийн аюултай дайсан бол цаг агаар болж тун ч магадгүй байна. Чи ямар замыг нь сонгов?

Фродо энэ үгийг санамсаргүй сонсоод нэлээд эрт эхэлсэн ярианы үргэлжлэл байна гэж таалаа.

- Харанхуйлсан газар руу ороход зам бүхэн аюултайг чи надаас дутуугүй мэдэж байгаа гэж би бодож байна - гэж Арагорн хариулаад – Гэвч бид энэ замыг туулах ёстой, тэгэхлээр Андуин хүрэх хэрэгтэй. Манант уулын өмнөд хэсгээр давах боломжгүй, эхлээд Ристанийн тал хүрэх хэрэгтэй. Саруман урвасан тухай чи өөрөө ярьсан. Тэгэхээр Ристанийг эзэлчихсэн байвал яах юм бэ? Тэгэхлээр тийшээ явж болохгүй, даваа өөд л дайрахаас өөр замгүй.

- Өөр бас нэг зам байгааг чи мартчихаж. Тандаж мэдээгүй, харанхуй зам боловч явж болохоор зам. Бид хоёр урьд нь ярьж байсан шүү дээ.

- Тэр замын тухай дахиж ярихыг хүсэхгүй байна, бусад замаар яагаад ч явж болохгүй гэж мэдтэлээ тэр замын тухай ярихгүй.

- Бид хаашаа явахаа өнөөдөр шийдэх ёстой

- За за, зөвшөөрч байна, гарах цаг болохоор энэ тухай дахиж ярья

Орой нь аянчид хоолоо идэж байх зуур Арагорн, Гэндальф хоёр зайдуухан зогсоод нам дуугаар ярилцангаа Хүрэн эврийн зүг байн байн харж байв. Уулын эгц хадан хажуу нүцгэн бөгөөд дүнсгэр, оргил нь нүсэр үүлсийн дунд шургажээ. Даваа тун ч таагүй харагдаж байлаа. Гэвч Арагорн, Гэндальф хоёр нөхөд дээрээ ирээд өнөө шөнө энэ даваагаар давах гээд үзнэ гэж зарлахад нь Фродо баярлав. Арагорн, Гэндальф хоёр өглөө ямар “тандаж мэдээгүй, харанхуй” замын тухай ярьсныг тэр мэдээгүй ч гэсэн айж байлаа.

- Магадгүй, Хүрэн эврийг дайсны тагнуулууд манаж байж болно. Цаг агаарын байдал ч гэсэн санаа зовоож байна. Даваан дээр бид цасан шуургатай тулгарч болно. Тиймээс бид аль болохоор хурдан явах хэрэгтэй. Бид наанадаж хоёр шөнө явж байж даваан дээр гарсан ч цаг агаар сайдахгүй байх. Өнөө орой эрт харанхуй болох учир ачаагаа янзалж, мөрөө баллах хэрэгтэй. Бид харанхуй болохоос өмнө амжих хэрэгтэй байна – гэж Гэндальф хэлэв.

- Ганц нэг юм нэмж хэлэхийг зөвшөөрнө үү - дуу цөөтэй Боромир зөвшөөрөл аваад – Би Цагаан уулнаас холгүй өссөн, өндөр уулан дээр олон удаа гарч байсан. Өндөр уулан дээр зун ч хүйтэн байдаг, одоо биднийг тэсгим хүйтэн хүлээж байгаа. Түүдэг гал түлэхгүйгээр бид даваан дээр хөлдөж үхэх аюултай. Миний ойлгосноор бид өдрийн цагаар явахгүй юм байна. Тэгэхээр бид одоо бэлд байгаа дээрээ хуурай мөчир цуглуулах хэрэгтэй. Хүн бүр нэг боодол мөчир үүрье.

- Билл хоёр боодлыг үүрнэ – гэж Сэм хэлээд - Чи биднийг аварна биз дээ найз минь – гэж Биллээс асуув.

Пони дуугараагүй боловч эзэн рүүгээ тун ч уйтгартай харж байв.

- Муугүй санал байна, гэвч бид зөвхөн онцгой нөхцөлд – хөлдөж үхэх үү, гал түлэх үү гэсэн сонголт тулгарахад л гал түлнэ – гэж Гэндальф зөвшөөрөв.

Аянчид эхлээд хурдан урагшилж байсан ч, өгсөх тусам зам бүдгэрч, нурсан хад асганд дарагдсан байлаа. Тэнгэрт үүл бүрхэж, аянчдыг харанхуй нөмрөв. Мөсөн салхи нүүр хайрна. Шөнө дунд дөнгөж үзэгдэх төдий зөрөг тэднийг хөтлөн баруун талдаа гүнзгий ангал, зүүн талдаа эгц хадан хясаатай нарийхан хавцал руу оруулав. Тэд замынхаа дөрөвний нэгийг ч туулаагүй байлаа.

Төдөлгүй харанхуй цасан шуурга эхэллээ. Юу ч харагдахгүй болж, Фродогийн өмнө явж байгаа Арагорн, Гэндальф хоёрт гар сунгахад л хүрэхээр ойрхон ч огт үзэгдэхгүй болов.

- Энэ харанхуй шуурга ч надад ёстой таалагдахгүй байна даа – гэж ард нь Сэм уухилан өгүүлж – Би цасан шуургыг өглөө дулаан хөнжилдөө хэвтээд цонхоор харах л дуртай.

Норгордод ийм цасан шуурга болбол хоббитууд баярлана даа. Харин энд бол ёстой хэрэг алга.

Хоббитанд цас барагтайд ордоггүй, жаахан цас орвол хоббитууд жаахан хүүхэд мэт баярладаг билээ. Бильбогоос бусад нь 1311 оны хатуу өвөл, цасанд дарагдсан Хоббитанд Брендидуимын мөсөн дээгүүр гарч ирсэн цагаан чононууд довтолсныг үзээгүй билээ.

Гэндальф зогсов. Түүний мөр, юүдэн дээр зузаан цас тогтжээ. Цас тэдний шагайгаар татаж байв.

- Үүнээс л би айж байсан юм – гэж тэр Арагорнд хэлээд – одоо чи юу гэж бодож байна, мөрч өө?

- Би ч бас айж байсан, гэхдээ бүгдээс бага айсан л даа. Умардынхан уулын цасан шуурганд дассан. Өмнөдийн ууланд цасан шуурга ховорхон болдог, боллоо ч гэсэн их өндөрт болдог юм. Бид өндөрт гарч амжаагүй л байна шүү дээ.

- Тэгвэл энэ чинь Дайсны хар шид биш үү? – гэж тэр хоёр руу ойртож ирсэн Боромир асуугаад – тэр Тортогт уулын цаг агаарыг ч захирдаг гэж манайхан ярьдаг юм. Гэхдээ тэр уулс бол түүний мэдлийнх, харин Манант уул Мордороос хол шүү дээ. Гэвч дайсны хүч өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа л даа.

- Хэрэв тэр умардын цаг агаарыг өмнөдөд авчирч байгаа бол гар нь их л уртасч байна даа – гэж Гимли хэлэв.

- Тэрнээс урт гартан үгүй - хэмээн Гэндальф бөвтнөв.

Тэднийг зогсч байх хойгуур шуурга намдаж, хэдэн мөчийн дараа цас ч орохоо болилоо. Тэд цааш хөдөллөө. Гэвч хагас лиг ч явж амжаагүй байтал дахин цасан шуурга булж, шуурганы хүч улам ихсэн, том том цасан ширхгээр гуядаж гарлаа. Аварга хүчит Боромир хүртэл урагш алхахад бэрх болсон ба хоббитууд цувааны сүүлд хоцорсхийж, шуурганы хүч нэмэгдвэл тэд цааш явж чадахгүй нь тодорхой боллоо. Фродо арай ядан хөлөө зөөж, Сэм араас нь уухилан зүтгэнэ. Пин, Мерри хоёр үг ч дуугаралгүй тэнхээ мэдэн зүтгэж, тэсвэртэйгээр алдартай гном Гимли хүртэл тамирдаж байв.

Тэд гэнэт дороо нам зогсов. Хэн ч дуугараагүй атал зогсёе гэж тохиролцсон юм шиг нэгэн зэрэг зогслоо. Эргэн тойронд нэгэн маш хачирхалтай чимээ гарч байна. Салхины исгэрээн дундаас хилэнт занал, чарлаа инээд, сөөнгө улиан тодоос тод сонсогдож байлаа.... Ямар ч гэсэн салхи шуурганы чимээ биш. Гэнэт тэдний дээрээс нэг том чулуу өнхрөв. Тэгснээ дахиад олон чулуу ар араасаа өнхрөн ирэв... Аянчид эгц хадан хананд наалдан зогсов. Том том чулуунууд хясааны ирмэг дээрээс дээр дээрээсээ нисэн хөл доор нь унаад харанхуй ангал руу өнхрөн одно. Байн байн нүргэлэн нижигнэх чимээ сонсдож, том том чулуу нисэн бууж өнхөрсөөр...

- Буцах хэрэгтэй – гэж Боромир хэлээд – Би нэг бус удаа уулын цасан шуурганд орж байсан, салхи хавцал дундуур яаж ульдгийг мэднэ... харин одоо бид салхины чимээнээс огт өөр юм сонсч байна! Энэ бол дайсны чимээ! Чулуу нурж байгаа нь ч байгалийн үзэгдэл биш байна.

- Салхи л ульж байна, гэхдээ Боромирын зөв, цаашаа явж болохгүй. Мэргэдийн зөвлөлд олон дайсан бий, гэхдээ тэд бүгдээрээ Сауроны холбоотон биш ч бидний дайсан – гэж Арагорн хэлэв.

- Эльфүүд бүр Дайсныг гарч ирэхээс ч өмнө энэ уулыг цусанд шаналтай гэж ярьдаг байсан юм - гэж Гимли өгүүлэв.

- Хэн саад хийж байгаа нь чухал биш, харин энэ саад давахын аргагүй саад гэдэг нь чухал байна - гэж Гэндалф хэлэв.

- Тэгээд одоо бид яах болж байна? - гэж Пин уйлах шахам асуув. Тэр хүйтэн хадан хананд наалдаад дагжталаа чичирч байв.

- Нэг бол эндээ зогсоод цаг агаар яахыг харна, эсвэл буцна - гэж Гэндалф хариулаад – Дээшээ авирах нь аюултай бөгөөд утгагүй. Би зөв санаж байгаа бол жаахан дээшлээд жим задгай налууд хүрнэ. Тэнд шуурганаас ч, чулуунаас ч, эсвэл өөр ямар нэг довтолгооноос хамгаалах арга байхгүй.

- Буцах ч утгагүй - гэж Арагорн үг нэмээд – энэ хананаас уулын бэл хүртэл нэг ч найдвартай хаалт байхгүй.

- Энэ хана тэгээд хаалт юм байх даа - хэмээн Сэм үглэсэн боловч Фродогоос өөр хэн ч сонссонгүй.

Хадгалагчид хананд наалдан зогссоор байв. Тэд бие биедээ наалдан, пони Билл тэдний өмнө зогсоод цасан шуурганаас хаацайлж байсан боловч эргэн тойронд нь багагүй хунгар тогтож, намхан хоббитууд цасанд дарагдах янзтай болов.

Фродо зүүрмэглэж, дараа нь цасан нүхэнд дулаацан, салхины исгэрээн чимээгүй болж, оронд нь ил гал дүрэлзэх чимээ сонсдож, задгай зуухны дэргэд Бильбо зогсч байх бөгөөд, дууных нь өнгө түүнийг зэмлэж байх аятай.

- Яагаад буцаад ирснийг чинь ойлгохгүй байна. Ердийн нэг цасан шуурганаас болоод энэ чухал аяныг тасалж яаж болох юм бэ?

- Би жаахан амрах гэсэн юм – гэж Фродо шивнэсэн боловч Бильбо галыг хурдан унтраагаад, түүнийг дулаахан буйдан сандлаас түлхэж буулгатал өрөөнд мөсөн харанхуй гулсан орж ирлээ...

- ...сонсч байна уу Гэндалф? Тэд толгойгоо хүртэл цасанд дарагдчихлаа шүү дээ - гэж Бильбо Боромирын дуу хоолойгоор хэлтэл Фродо тавлаг цасан нүхнээсээ сугаран агаарт дүүжлэгдэж байгаагаа мэдрэв. Тэгээд нойрноос сэрлээ.

- Эд нар бүр унтчихсан байна шүү дээ, унтаагаараа хөлдөж үхэх нь гэж – Боромир Фродог газарт буулгангаа хэлээд – яаралтай ямар нэг арга хэмжээ авах хэрэгтэй байна!

- Чиний зөв - хэмээн Гэндалф санаа зовнингүй хэлээд бүснээсээ ширэн бүрээстэй дашмаг

гарган ирж – хүн бүр нэг нэг балга – гээд дашмагаа Боромирт өгөнгөө - Энэ бол ер бусын хүчтэй ундаа – Илмадрисын бэлэг байгаа юм гэв.

Ганц балга сайхан амттай тэр ундаа Фродог бүлээцүүлсэн төдийгүй саяхны айдсыг нь ор мөргүй алга болгов. Бусад хадгалагчид ч сэргээд ирлээ. Шуурга урьдын адилаар уулгалж, цасан хуй улам эрчтэй боллоо.

- Түүдэг асаах уу? Бид хөлдөж үхэх үү, дулаацах уу гэдэг сонголтод бараг тулчих шиг боллоо – гэж Боромир асуухад Гэндалф:

- Одоо яая гэхэв, хэрэв энд Сауроны тагнуулууд байгаа бол биднийг аль хэдийн харчихсан - гэлээ.

Хадгалагчдад түлээ байсан (тэд Боромирын зөвлөгөөг дагаж хуурай түлээ түүжээ) боловч юм бүхнийг чаддаг мастерууд болох эльф ч, гном ч норсон түлээг асааж чадсангүй. Гэндалф асаахаар болов. Тэр овоолсон мөчир дээр очроо хүргээд: “Наур ан адриат аммин!” хэмээн хэлэнгүүт ногоовгор цэнхэр дөл харанхуйлсан цасан шуургыг гэрэлтүүлж, овоолттой мөчир дүрэлзэн асав. Салхи галыг улам ч хөгжөөж байлаа.

- Хэрэв давааг тагнуулууд манаж байгаа бол намайг энд явааг мэдсэн нь лавтай. Би тэдэнд ГЭНДАЛЬФ ЭНД БАЙНА гэсэн дохио өгчихлөө - гэж тэр баргар царайлсан мөртөө бахархалтэй хэлэв.

Гэвч Хадгалагчид түүний үгийг бараг сонссонгүй, гал хараад хүүхэд шиг баярлажээ. Түүдэг гал хөгжилтэйгээ дүрэлзэн асч, хадгалагчид цасан шуургыг үл анзааран, хайлсан цасны усан дээр гишгэлж, галаа тойрон зогсов. Тэдний ядарсан царайд галын дөл туяарч, эргэн тойронд цагаан шуурга уулгалан ульсаар байв.

Гэвч овоолсон мөчир дорхноо асч дууслаа.

Дөл намсч, бүүдгэрч байгаа гал руу сүүлчийн боодол мөчрөө нэмлээ.

- Зүгээр, одоохон үүр цайна. Шөнө дуусах гэж байна - хэмээн Арагорн тэднийг зоригжуулна.

- Шөнө ч яахав дуусдаг байж, ийм шуурган дунд өглөө болж байгааг ч мэдэх аргагүй - гэж Гимли хэлэв. Боромир галаас жаахан холдлоо.

- Шуурга намдаж байна, - гэж тэр хэлээд – Цас ч татарч байна -гэв.

Фродо гал руу ядарсан нойрмог нүдээр харж зогсов. Харанхуйгаас цасан ширхгүүд мөнгөлөг одод мэт гялалзан гарч ирснээ тэр дорхноо хайлан алга болж, эргэн тойронд шуурга улин, нэвгэршгүй харанхуй нөмөрсөн хэвээр. Фродо нойрмоглож нүдээ аньснаа найгаж унах дөхөөд хүндэрсэн зовхио нээхэд шуурга намдаж, бүүдгэрч буй цогны дээгүүр ганц нэгхэн цасан ширхэг залхурсан мэт эргэлзэж байхыг үзэв. Тэр толгойгоо өргөж, харанхуй тэнгэрийн дорно хэсэгт сулхан гэгээ татаж байхыг харлаа.

Саарал үүлэн дундуур нэвгэрсэн үүрийн гэгээ ядарсан аянчдад цасанд дарагдсан чив

чимээгүй уулсыг харууллаа. Тээр доор зузаан хунгар тогтож, цасан доорх зөрөг жим үл мэдэг таагдан, дахиад цасан шамарга тавина гэж занах шиг уулын дээгүүр үүлс хөшиглөнө.

- Баразинбар бууж өгөөгүй байна - гэж Гимли нам гүмийг эвдээд – Хэрэв бид цааш явахаар зоригловол дахиад цасан шуурга тавина. Аль болохоор хурдан буцах хэрэгтэй.

Буцах хэрэгтэй гэдгийг хүн бүр ухамсарлаж байсан ч яаж буцахаа мэдэхгүй байв. Зөрөг дээгүүр тогтсон хунгарт хоббитууд толгойгоо далд ортол шигдэхээр байв. Тэдний зогсч байгаа бяцхан талбайд цасан уул босчээ. Хадан хясааны нөмөрт цас тогтсон нь тэр!

- Гэндалф галт очроороо намхануудын замын цасыг цэвэрлэж өгнө - гэж Леголас хэлэв. Эльф эрийг цасан шуурга өчүүхэн ч сандаргасангүй, тэр л өглөө болтол сэтгэл санаагаар өөдрөг байв.

- Эсвэл Леголас тэнгэрт нисээд үүлийг хөөж, бидний замд байгаа хунгарыг нараар хайлуулна. Миний очир пийшин биш, харамсалтай нь цасыг асааж, шатааж болохгүй – гэж Гэндалф хариу хэлэв.

- Хэрэв ухаантан чадахгүй бол хүчтэн дийлнэ гэж манайхан ярьдаг юм. Шуурга эхэлж байхад тэр хясааг тойрч байсан - гээд Боромир аянчдаас зөргийг халхалж байгаа том хясаа руу зааж – эндээс тэр хүрэхэд хагас лигээс цаашгүй. Хэрэв биднээс хамгийн хүчтэй нь тэр хясаа хүртэлх замыг туулж зам гаргавал бид эндээс төвөггүй бууж чадна.

- Оролдоод үзэх хэрэгтэй. Бид хоёр хүчээ хавсрахад хагас лиг зам гаргаж л таарна – гэж Арагорн түүнийг дэмжлээ.

Арагорн багтаа хамгийн өндөр нь, Боромир хамгийн булиа нь байлаа. Тэр хоёр зам гаргахаар хөдөлж, Боромир урд нь орж явлаа. Зарим газарт цас мөрөнд нь хүрч, тэр анжис шиг ч юм шиг, маш их ядарсан сэлэгч ч юм шиг хунгар зүсэн урагшилна.

Леголас тэр хоёрыг инээмсэглэн харж байснаа шидтэн рүү харж:

- Ухаан, хүч хоёрт бас ур чадвар тусалдаг юм! – гэлээ.

Тэгээд цасан дээгүүр хөнгөхөн алхлан одов. Тэднийг Имладрисээс гарахад бөх зузаан ширэн гутал өгөхөд ганцхан Леголас өөрийнхөө хөнгөн эльф гуталтай гарсныг Фродо мэдэж байсан боловч анх удаа харж байгаа мэт сонирхон ажиглав. Леголасын гутал хунгар дээр бараг мөр үлдээхгүй байлаа.

- Баяртай! – хэмээн тэр Гэндалфт хөгжилтэй хашгиран хэлээд – Би та нарт нар олж ирэхийг хичээе – гээд урдаа яваа хоёрыг гүйцэж, гараа даллачихаад чангаар инээн хясааны цаагуур далд орлоо.

Хоёр хүн удаахан урагшилж, бусад нь араас нь дуугүй харж зогссоор, нөгөө хоёр хясааны цаагуур орж үзэгдэхгүй болов. Оргил дээр бөөгнөрч байсан үүл өтгөрч, хааяа нэг цасан ширхэг унаж байв.

Цаг орчим болсны дараа зам дээр эльф баатар гарч ирэв. Дараа нь уул өөд өгсч байгаа хоёр хүнийг харлаа.

- Би нарыг нааш нь авчирч чадсангүй - гэж Леголас хоббитууд руу нүдээ ирмэнгээ хэлээд – тэр өмнөд нутгийг ивээж байгаа бололтой, миний ойлгосноор энэ уулын орой дээрх жаахан үүл түүний санааг зовоохгүй байгаа бололтой. Гэвч би хүнд хөлтнүүдэд сайн мэдээ авчирлаа. Боромирын ярьсан хясааны цаана хангалттай зузаан хунгар тогтсон байна, хүчтэний омгийн манай хоёр баатар тэр саадны наана үхэхээр бэлтгэж байна, учир нь зөрөг хавцлаар гарна, хавцлаас гарах замыг хунгар хаасан. Тэгээд би хоёр хүчтэнд арван алхмаас илүүгүй өргөн цасан цайз руу дайрах гэж байна, цаана нь хоббитуудын шагайгаар татах цас байна гэж хэллээ.

- Тэгж бодсон юм аа, - Баразинбарын хорон санаа л энэ шуургыг дэгдээсэн байж таарна. Баразинбар гномууд болоод эльфүүдэд дургүй...- гэж Гимли эгдүүцэнгүй өгүүлэв.

- Аз болоход Баразинбар энэ багт хүмүүс байгааг мартсан бололтой – гэж эргэж ирсэн гондор баатар хэлээд – хүмүүс сул дорой биш гэдгийг онгиролгүй хэлье... Бид хоёр цасан хэрмийг гаталж, эльф маягаар цасан дээгүүр хөвж чадахгүй хадгалагчдад зам гаргалаа - гэв.

- Бид тэнд яаж хүрэх юм бэ? – гэж Пин асууж хоббитуудыг сандаргав.

- Бүү санаа зов - гээд Боромир - ядарсан ч гэсэн надад бяр байна. Арагорнд ч гэсэн. Бид та нарыг тэнд хүргэнэ, танаас эхэлье дээ, эрхэм хүндэт Пин гуай.

Пин гондор баатрын нуруун дээр авирч гарав.

- Сайн сууж аваарай, - Миний хоёр гар чөлөөтэй байх ёстой – гэж Боромир хэлээд өөрийн гаргасан зөргөөр доош уруудав. Түүний араас Арагорн Мерриг үүрэн хөдөллөө.

Цас дэвсэлж гаргасан замыг хараад Пин хүний хүчийг биширч байлаа. Нуруун дээрээ хүн суулгасан мөртөө Боромир хоёр гараараа замыг өргөсгөн үлдсэн хэд нь явахад хялбар болгож байлаа.

Удалгүй тэд нарийхан хавцлын аманд хүнээс хоёр дахин өндөр цасан хэрэмд тулж ирэв. Хунгарын зах нь нягт бөгөөд хурц, дундуур нарийхан зөрөг гарган тасалсан хадан хана мэт санагдаж байв. Мерри, Пин хоёр тэнд үлдэж, хоёр баатар дахин буцлаа.

Боромир хагас цагийн дараа Сэмийг үүрэн ирж, араас нь ачаатай пони хөтөлсөн Гэндалф, пони дээр суусан гном Гимли, эцэст нь Фродог үүрсэн Арагорн ирэв.

Арагорн хунгар ханыг дөнгөж өнгөрөв үү, үгүй юу нижигнэсэн их нүргээн сонсдож, хаа нэгтээ дээрээс том том чулуун мөндөр бууж, цасан хуй үүсгэв. Цагаан хуй намжсан хойно харвал хунгар хэрмэнд гаргасан гарцыг хад чулуугаар дүүргэсэн байлаа.

- Хангалттай, Баразинбар! - гэж Гимли хашгираад- Бид буцаж байна шүү дээ! Биднийг тайван орхи! – гэхэд ирсэн аянчид буцаж буйд уул өөрөө ч тайвширсан бололтой, чулуун мөндөр

зогсч, даваан дээрх үүл сарнив.

Хөл доорх цас улам нимгэрсээр аянчид удалгүй налуу руу бууж, өчигдөр анхны цасан ширхгүүд унаж байсан газарт хүрэв.

Бага үд дөхөж, ядарсан хадгалагчдын зогсч байгаа газраас цааш бэлийн уудам дэвсэг, намхан толгод, жижиг нуур цөөрмүүд, тахирласан гуу жалга, царсан төгөл, бут... үргэлжилжээ. Тээр доор тэдний хоноглосон хонхор харагдана.

Фродогийн хөл янгинан өвдөж, чөмгөндөө хүртэл даарсан тэрбээр хоол идэхийг хүсэвч, доош буух зам наанадаж хагас өдрийг барна гэж санахуйяа хоромхон зуурт нүд нь харанхуйлав. Нүдээ аниад нээтэл ямар нэг хар цэгүүд харагдав. Нүдээ арчаад хартал тунгалаг агаарт хар цэгүүд эргэлдсээр байв. Фродо сохорч байгаа юм болов уу гэж бодтол Арагорн:

- Дахиад л нөгөө шувуунууд – гэж хэлэх сонсдов.

- Одоо яах ч арга байхгүй - гэж Гэндальф шувуунууд руу харангаа хэлээд – Найз нөхөд байна уу, Дайсны тагнуулууд байна уу, зүгээр гэмгүй шувуунууд байна уу, хамаагүй бид тэртэй тэргүй доош буух ёстой. Карадрас шөнийн зочинд дургүй - гэв. Аянчид доош уруудахад хүйтэн салхи араас нь үлээж эхлэв. Хүрэн хаалга хаалттай байлаа.

Бүлэг 16

Харанхуйн аялал

Буур орой болсон хойно аянчид буудаллаж, харуй бүрий болж байхад ядарсан биеэ амраалаа. Баразинбарын зүгээс хүйтэн салхи хүүс хүүсхэн үлээнэ. Гэндальф дашмагаа нэг тойруулахад нэг нэг балгав. Оройн хоолны дараа зөвлөгөөн хийлээ.

- Өнөө шөнө бид амарна – гэж Гэндальф зарлав: - Даваанд бид бүгдээрээ их ядарсан...

- Дараа нь бид хаашаа явах вэ? - гэж Фродо асуувал Гэндальф:

- Хадгалагчдад хоёрхон л зам бий. Нэг бол эргээд Уудам хөндий орох, эсвэл урагшаа галт уул руу явах.

Гэндальф буцах тухай үг хэлэхэд Пиний царай баяртайгаар гэрэлтэж, Мерри, Сэм хоёр баярлан цочиж, Боромир, Арагорн хоёр огт дуулаагүй царайлж, Гимли, Леголас хоёр хүлээсэн байртай дуугүй суув. Фродо нөхдөө юу хүсч байгааг нь ойлгов. Тэд өөрөөр нь эхэлж үг хэлүүлэхийг хүсч байна.

- Буцах... – гэж тэр шийдэмгий бус үгээ эхэлсэн боловч дараа нь шийдвэртэйгээр: - ...Бид зөвхөн ялсныхаа дараа буцах ёстой гэж бодож байна. Эсвэл ялагдсанаа хүлээгээд шившигтэйгээр буцах. Би урагшаа явах саналтай байна – гэв.

- Би ч тэгж бодож байна – гэж Гэндальф түүнийг дэмжээд – буцна гэдэг бол ялагдсанаа хүлээн зөвшөөрсөн хэрэг, бид ялагдвал Дундад газрын чөлөөт ард түмнүүд бүгд мөхнө. Бүгдийг захирагч бөгж Уудам хөндийд үлдэнэ, яагаад гэвэл өөр нуух газар байхгүй. Дайсан яваандаа энэ тухай мэдээд бүх хүчээ Элрондын эсрэг хөдөлгөнө, эрт орой хэзээ нэг цагт Уудам хөндийн улс мөхнө, Дайсан бүхнээс хүчтэй ганц эзэн болно, харанхуйн хөшиг бүх Дундад газрыг нэлэнхүйд нь нөмөрнө. Хар бөгжтөнүүд бол аймшигтай дайснууд, гэвч тэдний эзэн бөгжийг гартаа оруулбал тэд хэнд ч, юунд ч дийлдэшгүй хүчтэй болно.

- Би Галт ууланд хүрэх хэрэгтэй гэсэн – гээд Фродо хүндээр санаа алдаж - Чи уулаар давах өөр зам мэдэх үү? – гэж асуухад:

- Мэднэ ээ найз минь, - гэж Гэндальф хариулаад – Гэвч энэ бол тун бүрхэг зам. Арагорн даваагаар давж чадна гэж найдаж байхдаа тэр замын тухай сонсохыг ч хүсээгүй.

- Хэрэв тэр зам энэ даваанаас бэрх юм бол ёстой бүрхэг зам юм байна! – гэж Мерри Арагорн руу харж хэлээд – гэвч бидэнд тэр замын тухай жаахан ч гэсэн ярьж өг л дөө, бид хамгийн муу юмыг мэдэж авъя.

- Миний ярьж байгаа зам Мориин агуй дундуур гардаг юм.

Гимли шидтэн рүү догдолсон шинжтэй харав. Тэр энэ нэрийг сонсоод л айж байлаа.

Хязгааргүй уудам Мориин орны үхлийн тэр агуйн тухай олон домог байдаг билээ.

- Мориин дундуур гардаг нүхэн гарц одоо байгаа эсэхийг хэн ч мэдэхгүй - гэж Арагорн хэлэв.

- Гэхдээ Морииг Ёроолгүй хар нүх гэж нэрлэдгийг хэн бүхэн мэднэ. Тэгээд ч тэр ёроолгүй нүх рүү орох ямар хэрэг байна? Давшгүй даваагаар давах гэж зүтгэх хэрэг юу байна? Мустангримийн тал руу явцгаая л даа. Мустангримчүүд бол манай эртний холбоотнууд, тэд биднийг Андуин хүрэхэд тусална. Изен голоор уруудаад Гондорын өмнө талаас орсон ч болно – гэж Боромир санал дэвшүүлэв.

- Харанхуйн хөшиг хүрээгээ тэлсээр байгаа – гэж Гэндальф энэ саналыг няцаагаад, -одоо ристанчуудад найдаад хэрэггүй. Чи тэнд нэлээд эрт очсон шүү дээ. Гол нь Ристанийн тал хүрэхэд Саруманы эдлэнгээр заавал дайрна. Цаг нь болоход би тэрэнтэй тооцоо бодно. Харин одоохондоо бөгж хадгалагч Изенгардад ойртож ч болохгүй. Саруман эрх мэдлийн төлөө улайрч байгаа учир бөгжийг гартаа хийх гэж заавал оролдоно. Тиймээс бидэнд Ристан хаалттай.

Одоо алсуур тойрох замыг ярья. Нэгдүгээрт хэтэрхий удаан явна. Бидэнд нэг жилээс дээш хугацаа хэрэгтэй. Хоёрдугаарт, баруун голын хөндийг Саруман, Саурон хоёр мэдээж манаж байгаа, эзэнгүй тэр тал газарт бидэнд нуугдах газар олдохгүй, тэнд эльфүүд байхгүй. Уудам хөндий рүү умар зүгт явж байхдаа чи Дайсны хувьд зүгээр л нэг явуулын хүн байсан учир тэр чамайг анзаараагүй. Одоо чи бөгж хадгалагчдын нэг учир чамд Фродогийн нэгэн адил аюул учирна. Хэрэв биднийг илрүүлэх л юм бол үхлийн аюул учирна...

Биднийг аль хэдийн илрүүлсэн байх вий гэж айж байна. Хүрэн хаалганы дэргэд илрүүлсэн байж мэднэ. Биднийг Дайсны тагнуулууд хараанаасаа алдахын тулд бид тэднээс дээд зэргээр нуугдаж явах ёстой. Уулыг тойрох биш, даваа өөд дайрах биш, уулан доогуур нуугдаж явах хэрэгтэй байна, Мориин агуй бол хамгийн тохиромжтой зам. Дайсан биднийг түүгээр явна гэж яасан ч бодохгүй.

- Хэн мэдэх вэ дээ, - гэж Боромир эсэргүүцээд – Бидний хаана явааг тэр мэдэх юм бол бид тэр нүхнээс хэзээ ч гарахгүй л байх. Дайсан Мориинг өөрийнхөө Хар цамхагт байгаа шиг эзэгнэдэг гэж ярьцгаадаг. Ёроолгүй хар нүх гэж нэрлэдэг гээд бод л доо!

- Дуулсан болгондоо бүү итгэ, Мориин Дайсан огт эзэн суудаггүй. Тэнд орхууд байж магадгүй, гэхдээ би тэгж бодохгүй байна – орхуудын армийг Гоонь уулын дэргэд болсон таван их тулаанаар бут ниргэсэн. Манант ууланд орхууд дахин үзэгдэж байгаа тухай Уулын бүргэдүүд саяхан мэдээлсэн... гэвч тэд Морийд хараахан нэвтрээгүй гэж найдаж байна.

Харин тэнд бид Балины багахан боловч эрэлхэг бүлэгтэй таарч магадгүй, тэгвэл орхуудаас айх юм огт байхгүй. Ямар ч байлаа гэсэн Мориин бол бидний цорын ганц зам, өөр зам байхгүй – гэж Гэндальф ярив.

- Би чамтай хамт явна аа Гэндальф! – гэж Гимли хэлээд би эртний домгуудаас айхгүй. Гэхдээ аль эрт хаагдсан үүдийг эрж олох хэрэгтэй шүү дээ!

- Сайхан хэллээ, миний найз Гимли – гэж Гэндальф инээвхийлэн хариулаад – Би үүдийг олно, нээж ч чадна. Гномтой хамт яваа цагт бид төөрөхгүй. Би нэг удаа сураггүй болсон Траиныг хайж Мориин агуйд орсон, тэгээд амьд л гараад ирсэн байгаа биз дээ. Би тэгэхэд Морийг хөндлөн гаталсан юм шүү, Арагорн – гэж шидтэн хэлээд түүн рүү харав.

- Би ч гэсэн нэг удаа орж байсан, Хар голын талаас орсон юм. Бас л амьд гараад ирсэн. Гэхдээ хоёр дахь удаагаа ормооргүй байна. Дэндүү их бэрхийг туулсан.

- Би анх удаагаа ч ормооргүй байна - гэж Пин бувгнав.

- Би ч гэсэн орохыг хүсэхгүй байна – гэж Сэм аяархан хэлэв.

- Тийшээ орохыг хүссэн хэн ч алга – гэж Гэндальф хэлээд – гэвч бид хар гол орох хэрэгтэй. Тиймээс би хэн Моригоор явж Андуин хүрэхийг зөвшөөрч байна гэж асууж байна.

- Би! – хэмээн Гимли шууд хэлэв.

- Би ч бас – гэж Арагорн хэлээд - Чи бид үхэж ч магадгүй шүү гэж надад хэлэхэд даваа руу дайрахаас татгалзаагүй, бид бараг хөлдөж үхэх дөхсөн. Би чамтай хамт Мори руу явна аа, Гэндальф. Гэхдээ нэг зүйлийг сана! Тэнд бидэнд биш, чамд л гол аюул тулгарна шүү!

- Би тэр хар нүх рүү зөвхөн бүх хадгалагчидтай хамт шургахыг зөвшөөрч байна. Хоёр намхан тийшээ явахыг хүсэхгүй байна. Леголас, Фродо хоёр бол гол хадгалагч! - Мерри юу ч хэлээгүй байна.

- Би Мори руу явахыг эсэргүүцэж байна – гэж эльф дайчин хурдхан хэлэв.

Бүгд Фродо, Мерри хоёрыг харлаа. Хоёр хоббит удаан дуугүй суув. Тэгээд Фродо нам гүмийг эвдэж:

- Би Мори руу орохоос айж байна, гэвч Гэндальфын зөвлөгөөг няцаахыг хүсэхгүй байна. Шийдвэр гаргахаа өглөө хүртэл азная. Дэндүү харанхуй, уйтгартай байна. Аймшигтай ч байна. Салхи яаж ульж байгааг сонсооч!

Аянчид царс модны мөчир доогуур нуугдав. Тэгээд яриагаа зогсоож, чимээ чагналаа. Салхи нүцгэн мөчирт исгэрэн хатсан өвсийг сэржигнүүлнэ. Гэвч энэ уйтгарт чимээн дундуур уулын хавцлаар шуурга улих мэт гунигтай, тасалданги улиан сонсдож байлаа. Арагорн тэр чимээг удаан сонсоход хүрэв.

- Салхи гэж үү? – гэж тэр босон харайгаад – Салхи чонын улианаар ульдаггүй! Чонодолоохууд дахиад Манант уулаар даваад ирж!

- Ан эхэлсэн бололтой гэж Гэндальф хэлээд – Тэгээд шийдвэрээ өглөө болтол хойш тавих хэрэг байна уу? Хэрэв бид үүр цайтал амьд байлаа гэхэд Ристанийн тал руу гарч чадахгүй нь байна шүү дээ.

- Тэр Мори чинь хэр хол байдаг юм бэ? -гэж Боромир асуув.

- Чи Баруун хаалга эндээс хэр холыг мэдэхийг хүсч байна уу? Бүргэдэд бол... арваад лиг. Газар дээрх хамгийн дөт жимээр бол арван наймаас хориод лиг.

- Мориид нуугдах хэрэгтэй, орхуудаас айлаа гээд чононуудаас зайлах юм биш!

- Тийм нь ч тийм, - гэж Арагорн зөвшөөрөөд, илдээ амархан сугарч байгаа эсэхийг шалгангаа – Гэвч нөгөө талаар, хаана чоно байна, тэнд орх байна, хавцалд чоно олноороо, агуйд орх үй олноороо.

- Би Элрондын үгэнд ороогүй тун тоогүй юм боллоо - гэж Пин Сэмд шивнээд – Миний бөгж хадгалагч гэж юу байх вэ дээ? Энэ улианыг сонсохоор үнхэлцэг хагарах гэж байна. Амьдралдаа хэзээ ч ингэж айж байсангүй. Бандобрас Быкобор – дэмий л миний өвөг байж дээ.

- Тэнэмэлийг босон харайхад миний зүрх дэлбэрчих шахсан, одоо ч гэсэн. Зүгээр дээ, айх юмгүй. Арагорн, Боромир хоёр ихийг үзэж, бүхнийг ялсан баатрууд, Гимли бүх гномын хамгийн шилдэг нь, Леголас ч гэсэн хамгийн шилдэг эльф. Хөгшин Гэндалф бол жинхэнэ шидтэн. Үгүй ээ, биднийг чоно барьж идэхгүй.

Аянчид хонхорт хонохоор төлөвлөсөн боловч чонодолоохуудаас хамгаалахын тулд хажуугийн намхан толгой дээр гарав. Тэнд том том саарал чулуугаар хашлага хийсэн гурав дөрвөн хөгшин царс байсан бөгөөд хашлаганы зарим хэсэг нь нурсан байв. Шөнийн харанхуйд чононууд тэднийг амархан олохыг аянчид ойлгож байсан ч гэсэн хуурай мөчрүүдийг хуга татан авч даруйхан гал асаав.

Хоёр харуул гаргаад бусад нь галаа тойрон сууж зүүрмэглэх аядав. Пони Билл айсандаа дагжин чичирч, дөнгөж сая хорин лиг газар давхиад ирсэн мэт байдгаараа хөлөрчээ. Улиан одоо тэдний эргэн тойрноос ойртон, шөнийн харанхуйд хос улаан галууд гялс гялсхийж эхлэв. Гэнэт чулуун хашлагын нурсан хэсэгт лут том чонодолоох гараад ирэхийг аянчид харав. Тэр хашлагын ангархай дээр зогтусан зогсоод бусдадаа дайрах дохио өгч байгаа бололтой нэгэнтээ сөөнгөтөн улив.

Гэндалф харанхуйд гялалзан харагдах очроо өргөөд араатны өмнөөс алхаж:

- Сауроны золбин нохой чи үтэр түргэн тонил, чиний өмнө Гэндалф зогсч байна. Арьс чинь чамд үнэтэй бол эндээс тонил! – гэж зориуд аяархан зандрав.

Араатан нэгэнтээ богинохон архираад ухасхийхэд тавьсан нумын хөвч тасхийн аварга араатан ганцхан ганхийгээд газарт унав. Хоолойд нь сум зоолттой харагдлаа. Леголас хоёр дахь сумаа татсан боловч заналт улаан галуудын хүрээ сарнилаа. Гэндалф, Арагорн хоёр хашлага дээр очиж харвал толгойн эргэн тойронд чонодолоохууд алга болжээ. Толгойлогчгүй болсон сүрэг таран одож, аянчид нам жим харанхуйд үлдэв.

Шөнө дунд өнгөрч, үүр цайх дөхөж байгаа бололтой, баруун талаас сар хөөрч, байн байн сэмэрхий үүлэн цаагуур орон дээшилсээр, цонхигор гэрэл нь үе үехэн цухалзана. Гэнэт олон хоолойн догшин чанга улиан Фродог бүрэг бараг нойрноос сэрээв. Толгойг чимээ гаргалгүй

бүсэлсэн чонодолоохууд тал бүрээс дайрчээ.

- Галд мөчир нэм! - гэж Гэндалф хоббитуудад тушаагаад – Илдээ сугал! Нуруугаа нийлүүлэн тулалдаанд!

Түүдэг галын гэрэлд намхан чулуун хашлага дээгүүр саарал сүүдрүүд харайн давж байгааг Фродо харав. Арагорн цахилгаан мэт гялсхийн цавчихад хоолойгоо тас цавчуулсан аварга араатан хөлдүү газарт лүсхийн унаж, Боромирын илд хүйтэн гэрэл цацруулан гялсхийхэд хоёр дахь араатны толгой хийсч, Гимлийн сүхэнд гурав дахь толгой өнхөрч, Леголасын суманд дөрөв дэх нь унасан боловч олон саарал сүүдрүүд хашлага дотор бөөн бөөнөөр орж ирлээ.

Фродо Гэндалф руу горьдлого тээсэн нүдээр харав. Шидтэний бие гэнэт бараг тэнгэрт тултал томорч, шидэт очир нь нүд гялбам гэрэл цацруулан, чулуугаар сийлсэн аварга биетэн мэт Гэндалф дайрч буй чонодолоохуудаас тэднийг хамгаалан хана мэт зогсов. Толгойн дээгүүр:

- Наур он адриат аммин! – гэсэн шидэт тарни нүргэлэх мэт цуурайлав. Царс модод руу очроо чиглүүлмэгц тэр дороо авалцан асч, толгой дээр тулааны талбарыг нарлаг өдөр мэт гийгүүлсэн аварга том түүдэг гал дүрэлзэн тэнгэр өөд аварга галан цэцэг цоролзов. Юу ч харахаа больж сохорсон чонодолоохууд учраа олохгүй ухарч хэлэхэд Хадгалагчдын илд дөнгөж сая галан хөөрөгнөөс гаргасан мэт очис цахилуулан айж алийгаа алдсан араатнуудын толгойг хяргаж, Леголасын сум агаар зүсэн исгэрч, нэгэн лужир том хар чонодолоохыг зүрхийг сүвлэн унагаахад үлдсэн чонодолоохууд гэнэт ухаан орсон юм шиг сүүл хавчин зугтаав.

Олон зуун настай царс модод удаан шатаж, толгойн дээгүүр утаан үүл бүрхэн, үүр цайхад сүүлчийн гал улалзан унтарч, моддын гол цогшин улайж байлаа.

- Би чамд юу гэж хэллээ – гэж Сэм илдээ хуйлахдаа Пинд ядрангуй хэлээд – Хөгшин Гэндалфыг зүгээр л хүрч ирээд идчихгүй шүү, шидтэн гэдэг чинь шидтэн л байдаг юм!

Эргэн тойрноо харахад нэг ч чонодолоох үлдсэнгүй, бүгд тонилжээ. Гайхалтай нь нэг ч чонодолоохын хүүр алга байв! Леголас дуугүйхэн сумаа түүж авлаа. Тэр нэг ч алдаагүй гэдэгтээ итгэлтэй байсан бөгөөд нэг сумнаас бусад нь /зөвхөн зэв нь үлдсэн байв/ бүгд бүтэн байлаа.

- Тийм байх аа, - гэж Гэндалф хэлээд – Эд бол зүгээр нэг чонодолоохууд биш, сүг чонодолоохууд байна. Сэг ч үлдээгүй байгааг харахгүй юу! Хурдхан цайлаад хөдөлье – гэлээ.

Цаг агаар дахиад хувирлаа. Аянчид нэгэнт даваанаас холдсон учир цасан шуурга хэрэггүй боллоо гэж үзсэн агуу хүчирхэг шидтэн тушаал өгсөн юм шиг салхи үүлсийг түргэн зуурт хөөж, тэнгэр цэлмэхэд салхи зогсов. Уулын цаанаас нар яаралгүйхэн гарч ирлээ. Агаар тунгалаг байхад тэгш талаар явж байгаа хадгалагчид алсаас харагдахаар байсан ч аянчид нуугдаж сууж төвдсөнгүй.

- Мориид гэгээтэй байхад хүрэх хэрэгтэй, тэгэхгүй бол ерөөсөө хүрч чадахгүй. Хорин таван лиг хол зай биш, гэвч Арагорн эндхийн замыг мэдэхгүй, би ч гэсэн энд ганцхан удаа ирсэн болохоор бид хурдлах хэрэгтэй байна – гэж Гэндальф баргар царайтай өгүүлэв.

Хаалга тээр тэнд байгаа – гэж шидтэн яриагаа үргэлжлүүлэн манант уулын бараа сүүмэлзэж байгаа зүүн өмнө зүг рүү очроороо заагаад – Биднийг цасан шуурга даваанаас хөөхөд би өмнө зүг рүү эргэж, нурууны дагуу явсан юм. Тэгвэл Мориид бага ч гэсэн дөхүү болно. Энэ зам бидэнд заавал хэрэг болно гэж миний зүрх мэдрээд байсан юм. Бид хаалгыг хурдан олж, харанхуй болохоос өмнө сүгнүүдээс нуугдаж чадна гэж би найдаж байна.

Гимли хурдан тэнд хүрэх сэн гэж тэсч ядахдаа Гэндальфын хажууд түрүүлэн алхаж байв. Нэгэн цагт Мориин хаалганы ойролцоо эльфүүдийн Сираннона /Шалиг гол/ гэж нэрлэдэг жижиг голыг тэтгэдэг нэгэн булаг байсан бөгөөд Гэндальф тэр голыг эхэлж олоод дараа нь түүнийг даган хаалга руу хүрэх бодолтой байв. Гэвч тэр гол ширгэчихсэн юм уу, шидтэн чиглэлээ буруу авсан юм уу, олдохгүй л байв.

Аянчид тахир муруй ан цав, хүрэн чулуугаар дүүрэн хадархаг талаар нааш цааш хэрэн явсаар. Шидтэн нэг баруун тийш, нэг зүүн тийш хэрэн бэдрэвч гол байдаггүй, замгүй газраар яваад орой гэхэд Хаалга хүрч чадахгүй нь гэдгээ бүгд ойлгож байлаа. Үржил шимгүй тал эцэсгүй үргэлжилж, хатаж хагарсан хүрэн хөрс, хүрэн улаан чулуу, хайрганаас өөр юу ч үл харагдана. Эргэн тойрон нэг ч араатан, жигүүртэн харагдсангүй. Аянчид Гэндальфын араас дуугүй алхаж, энэ тал дээр шөнийг өнгөрөөвөл юу болох тухай бодохгүйг хичээж байв.

Гимли ойрхон салж, нэг том хадан дээр гарснаа Гэндальфыг дуудав. Шидтэний араас бусад нь дагалаа. Гимли баруун тийш заав. Тэр зүг харвал ширгэсэн голын чулуурхаг голдрил байх бөгөөд түүний эргээр нэгэн цагт улаан чулуун хавтангаар хашиж байсан бололтой зам зурайж байв.

- Арай гэж олдов уу! - гэж Гэндальф дуу алдаад – Энэ гол яачихсан нь сонин байна. Гэхдээ яасан ч байлаа гэсэн энэ бол Сираннона буюу Шалиг гол мөн байна. Урагшаа нөхөд минь, яарах хэрэгтэй байна!

Ядарсан аянчид сүгнүүдээс нуугдах газар олдоно гэсэн найдвар төрсөнд урамшин алхаагаа түргэтгэлээ.

Цаг явсаар, үд өнгөрч нар баруунаа ташиж эхэллээ. Тэд түр зуурхан зогсч идэж ууж аваад хөдөллөө. Өмнө нь Манант уул сүүмэлзсээр байвч зам гэнэт гүн жалга руу орсон тул зөвхөн цаст оргил л цухуйж харагдана.

Хэдэн цаг яваад зам эргэлээ. Урьд нь тэд өмнө зүг рүү явж, зүүн талд нь толгод байсан бол одоо зүүн зүг рүү огцом эргэжээ. Төдөлгүй голын голдрил нэгэн цагт булаг байсан бололтой хонхор бүхий хадан хясаанд тулав. Хясаанаас ус оргилж байсан бололтой, одоо зөвхөн дөнгөж ажиглагдам нарийхан голдрил үлджээ.

- Сираннона ширгэжээ. Гэхдээ бид Хаалга руу эргэлзээгүй дөхөж байна. Энэ булгийг Мориин босго гэж нэрлэдэг байсан юм, хэрэв би андуураагүй бол зүүн талд нь хаданд шатны гишгүүр

гаргасан байгаа, зам алсуур тойроод Босгоны дээгүүр гарч Сиранноны хөндийн баруун налуу руу очно. Хөндий зүүнээс баруун тийш үргэлжилсэн, /гномууд булгийн хөндий гэдэг/, шат нь хөндийн баруун үзүүрт байдаг, тэнд хаалга байгаа, булаг ч бий. Шат байна уу, үгүй юу харцгаая – гэж Гэндальф өгүүлэв.

Тэд шатыг амархан олж Гимли түрүүлэн, араас нь Гэндальф, Фродо Булгийн хөндий өөд яаран өгсөв. Хөндийн оронд нуур харлан цэлийж үзэгдэв. Жаргах нар тэнгэрийг алтдан байвч үхмэл хар хүрэн өнгөт нуурын мандалд тэнгэр, уул, нар аль нь ч үл тусна. Сираннона голыг хадан нуранги хаасан учир хөндий усанд автсан ажээ. Хар нуурын цаана харанхуй, сүрлэг хадан хясаанууд сүндэрлэнэ. Хадан хананд хаалга байтугай өчүүхэн ангархайг ч Фродо олж харсангүй.

- Морийн хана гэдэг чинь энэ дээ. Нэгэн цагт энд Баруун хаалга буюу хүмүүсийн хэлээр Эльфийн хаалга байсан юм, учир нь бидний явж ирсэн зам Булгийн хөндийг Остраннтай холбож байсан юм. Шууд зам хаагдсан байна, энэ үхмэл нуурыг сэлж гарах хүсэлтэй хэн ч байхгүй байх. Тэгээд ч энэ нуур их гүн байх – гэж Гэндальф хэлэв.

- Буцаж яваад гол замаар өгсөх гээд үзье. Зам хаагдаагүй байсан ч гэсэн бид буцах байсан, Билл шатаар өгсч чадахгүй – гэж Гимли санал гаргав.

- Биллийг Мории руу авч орохгүй. Тэнд пони ч багтахгүй нарийхан гарцууд байдаг юм - гэж Гэндальф хэлэв.

- Билл хөөрхий, Сэм ч гэсэн. Тэр юу гэх бол? Хайртай мориноосоо салах нь дээ – гэж Фродо бувгнав.

- Тийм ээ, харамсалтай байна – гэж Гэндальф хэлээд - Пони бидэнд үнэнчээр зүтгэсэн, гэтэл бид түүнийг хувь заяанд нь даатгаад орхиж байна. Биллийг авч явах хэрэггүй гэж би хэлсэн шүү дээ. Хөнгөн ачаатай явъя гэсэн. Учир нь би бүр эхнээсээ л энэ замаар явахаас өөр аргагүй болох байх гэж бодож байсан юм.

Үдшийн цайвар гэгээ бүүдгэрэн харанхуй болж, тэнгэрт одод гялалзаж эхлэх үеэр туйлдаж ядарсан аянчид Морийн хананаас хоёр лиг орчим зайтай хөндийн хойт налууд гарч ирэв. Өргөнөөрөө хоёр лиг, уртаараа дөрвөн лиг орчим хөндий нарийсч, нэг талаасаа хадан хясаа, нөгөө талаасаа усаар хавчигдсан нарийхан зурвас газар болж хувирав. Хадгалагчид харанхуй болохоос өмнө хаалгыг олохын тулд нуурын эргээр зүүн зүг рүү бараг гүйх шахам явлаа.

Хананд дөхөж иртэл тэдний замыг хадан хясаа, нуур хоёрын хоорондох нарийн зурвас газрыг тасалсан суваг хаалаа. Сувгийн ус хар, дээгүүрээ ногоовтор замагтай бөгөөд хясаанаас зуураад живсэн амьтны гар шиг харагдана. Гимли зоригтойгоор ухасхийхэд хэн ч түүнийг барьж авч амжсангүй, суваг гүехэн боловч ёроол нь халтиргаатай байжээ. Гимли халтирч унах дөхсөн боловч тэнцвэрээ хадгалж чадаад хуурай газар дээрт гарав. Бусад нь түүний араас цуварч, Фродо хүйтэн ногоон уснаас сэжиг хүрч, бие нь агзасхийв.

Цувааны сүүл мушгисан Сэм чичирч байгаа пониг хуурай газарт хөтлөн гаргахад ус цалгих сонсдож, нууран дотроос том загас үсрэн гарснаа буцаад орчих шиг болов. Эргэж харвал

нуурын мандалд дугариг долгион тарж байгаа нь үдшийн бүдэг гэгээнд үзэгдэв.

Гэндальф хурдан хурдан алхахад хоббитууд арай ядан гүйцэж байв. Тэд нуур руу унахаас эмээж, хясаанд бараг наалдан, заримдаа хадан ханыг түшиж явлаа. Нэг лиг орчим алхсаны дараа үдшийн бүрийд модод сэрийж үзэгдэв. Хананы дэргэд хоёр аварга царс байх ба нууран дунд хоёр эгнээ илжирч байгаа моднууд харагдана. Зам энд дуусчээ.

- Эцсийн эцэст ирлээ дээ! - гэж Гэндальф баяртай дуу алдан – Эльфийн их зам энд дуусдаг юм. Гномууд эльфүүдтэй чөлөөтэй худалдаа хийхийн тулд Баруун хаалгыг нүхэлж гаргасан, эльфүүд дотны найрамдлаа мөнхлөхийн тулд энд хоёр эгнээ царс суулгасан юм. Царс бол Остранны бэлгэ тэмдэг.

- Энэ найрамдал гномуудаас болж тасарсан гэж би нэг ч удаа сонсоогүй юм байна гэж Гимли хэлэв.

- Энэ найрамдал эльфүүдээс болж тасарсан гэж би нэг ч удаа сонсоогүй юм байна гэж Леголас хэлэв.

- Би аль алиныг нь байн байн сонсч байсан. Одоо хэн нь зөв, хэн нь бурууг шийдэх цаг биш. Та хоёр найз хэвээрээ үлдэнэ гэдэгт би найдаж байна. Надад та нарын туслалцаа маш их хэрэгтэй байна. Найзууд л хамтарч ажиллаж чаддаг. Бид бүрмөсөн харанхуй болохоос өмнө Хаалгыг олж нээх хэрэгтэй – гэж Гэндальф хэлэв.

- Харин та нар бид гурвыг хаалга нээмэгц яаралтай ороход бэлтгэ. Биллээс энд салах учир ачааг нь буулга. Дулаан хувцас авахгүй байж болно. Мориид ч, дараа нь бидэнд дулаан хувцас хэрэггүй. Хоол хүнс, савтай уснуудаа хувааж үүрцгээ – гэж тэр бусдад нь тушаав.

- Биллийг орхино гэж юу гэсэн үг вэ? – гэж Сэм айсан, үзэн ядсан дугаар асуугаад – Би түүнгүйгээр нэг ч алхахгүй! Хөөрхий амьтныг хаа хол ачиж явчихаад одоо чонодолоохын хоол болгож хаях гэж үү?

- Надад ч гэсэн харамсалтай байна. Гэвч найз минь, эзэн, илжиг хоёрынхоо аль нэгийг сонгох цаг болсон. Хаалга нээсний дараа чи энэ амьтныг Мории руу хөтлөөд орж чадахгүй, энэ хар нүх рүү тэр багтахгүй гэдгийг ойлгох хэрэгтэй.

- Тэр надтай хамт багтана. Би түүнийг танай тэр хараал идсэн хар чонодолоохуудын хоол болгохгүй!

- Хоол болох нь хаашаа юм, - гээд Гэндальф понийн толгойг эелдгээр илж: - Чи Уудам хөндийд их юм сурсан, Билл. Буцах замдаа болгоомжтой, биеэ хайрлаж яв, эзэн хичээвэл заяа хичээдэг юм. Бидний хэн нь ч өөрийнхөө хувь заяаг яаж төгсөхийг мэдэхгүй, гэвч бид ямагт сайн сайханд найдаж явдаг... Бидний хэн ч чиний хувь заяаг мэдэхгүй - гэж хэлээд Сэм рүү эргэж: - Билл амьд гарна гэдэгт найдацгаая - гэв.

Сэм юу ч хэлсэнгүй. Тэр понийн дэргэд зогсоод уйлав. Цаадах нь түүн рүү налж, юун тухай яриа болж байгааг ойлгосон байртай гүн санаа алдав. Сэм понийн ачааг буулгаж, бусад нь

ачаагаа янзлан авах юмаа авч үүргэвчдээ хийлээ.

Тэд ачаагаа хувааж аваад Гэндальф юу хийж байгааг сонирхов. Тэр юу ч хийсэнгүй, зүгээр зогсоод хана руу нүдээрээ өрөмдөх гэж байгаа мэт тас ширтэнэ. Леголас түүнд наалдан зогссон байх бөгөөд яагаад ч юм нүдээ аньжээ. Гимли ойр хавиар хана руу сүхээрээ тогшин дуугүй алхана.

- Бид ч яахав, Мориин руу ороход бэлэн боллоо. Харин нөгөө хаалга нь хаана байгаа юм бол доо? – гэж Мерри дуугарав.

- Хаалгыг гномууд хийсэн бол хэн ч олж харж чадахгүй. Хаалга гаргасан мастер ч түүнд шингээсэн шидэт тарнийг мэдэхгүй бол олж чадахгүй – гэж Гимли даруухан боловч бахархалтай хэлэв.

- Тийм ээ, гэхдээ Баруун хаалга нууц байгаагүй. Түүнийг найз эльфүүддээ зориулж гаргасан. Хэрэв манай эринд л түүнийг өөрчилчихөөгүй бол мэддэг хүн амархан олоод нээж болно – гэж Гэндальф өгүүлэв.

Гэндальф дахиад хана руу харлаа. Харуулын хоёр царсны хооронд хана ер бусын толигор байсан тул Гэндальф ханыг гараараа тэмтэрч, ямар нэг ойлгомжгүй үгс хэлж байв. Тэгснээ аянчид руу хараад:

- За одоо? Та нар одоо ямар нэг юм харж байна уу? – гэж асуув.

Дөнгөж хөөрч байгаа сар ханыг гэрэлтүүлж байсан боловч аянчид ханан дээрээс юу ч олж харсангүй. Гэвч дараа нь хананы гадаргуу дээр нарийхан мөнгөлөг зураас тодорч, улам улам тодорсоор мэл гайхсан аянчдын нүдний өмнө гайхалтай уран зураг үзэгдэв.

Дээд талд нь чамин угалзлуулан бичсэн эльф бичиг, түүний доор титэм болон долоон одтой алх дөш, түүний доор хананы дэргэд байгаа хоёр царс, царснуудын хооронд туяа цацруулсан од дүрсэлжээ.

- Дарины сүлд! - гэж Гимли алх дөш хоёрыг зааж дуу алдав.

- Остранны сүлд - гэж Леголас хэлэв.

- Бас Феанорын од - гэж Гэндальф туяа цацруулсан одыг заагаад – энэ зураг зөвхөн сар юм уу, одны гэрэлд, одоо бараг хэн ч мэдэхгүй эртний эльф хэлний аялгуун дор л үзэгддэг. Би тэр тарнийн үгсийг арай гэж саналаа.

- Энд юу гэж бичсэн юм бэ? – гэж Фродоо асуув. Би эльфийн рунг бичгийг мэднэ, гэтэл уншиж чадахгүй байна.

- Гайхах юм байхгүй. Энэ бол эртний эльф бичиг, Бильбо чамд шинэ эльф бичиг заасан. Би хуучин бичгийг нь мэдэх боловч энд хамгийн гол зүйлийг бичээгүй байна. Энд: “Марийн хаан Дарины Баруун хаалга шидэт тарниар нээгдэнэ” гэсэн байна. Доор нь жижиг үсгээр: “Нарви би энэ Хаалгыг үйлдэв, Остранны Селебримбэр тарнийг шингээв. Хэлээд ор” гэжээ.

Фродогийн хөлөөс хэн нэг нь зуурч авахад тэр өвдсөндөө нэг чанга хашгираад өнхрөн унав. Билл маш их айсан байртай чангаар янцгааснаа Морийн ханын дагуу давхиж харанхуйд уусан алга болов. Сэм түүний араас дуудан гүйсэн боловч эзэн нь хашгирах дууг сонсоод хараал тавин эргэж гүйлээ. Бусад аянчид эргэж хараад нуурын усан дотор аварга том могой эрчлэн тонгочиж байгаа мэт булгилан давалгаалж байхыг харав.

Нэг том могой... гэхдээ яг могой биш, могойтой төстэй мөртөө хачин нялцгай хайрстай, үзүүртээ хүнийх шиг хуруутай тэмтрүүл бүхий муухай амьтан эрэг дээр үсрэн гараад Фродогийн хөлөөс барьж аваад нуурын өмхий ногоон ус руу чирж байв. Сэм юу ч бодолгүйгээр илдээ сугалан дөнгөж харагдаж байгаа тэмтрүүлийг нь цавчтал могойн өнгө бүүдгэрэн хөдөлгөөнгүй болж, Фродо хөл дээрээ ухасхийн босоод найган гуйвсаар агуйн нээлттэй хаалга руу оров.

Сэм ч түүний араас агуй руу ухарлаа. Оволзон давалгаалж, хөөсрөн байгаа нуурнаас дахиад хориод тэмтрүүлт аймшигийн амьтан гарч ирэхэд агаар тэр чигээрээ өмхий болов.

- Агуй руу! Шатаар дээшээ! Хурдал! – гэж Гэндальф арагш үсрэн ухрангаа хашгирлаа.

Хадгалагчид нэг хэсэгтээ хөдөлж чадахгүй байснаа ухаан ороход (Фродог ганцхан Сэм л аврахаар гүйсэн). Сэм, Фродо хоёр шатаар өгсч, Гэндальф арагшаа ухран шат руу дөхөх үеэр тахиралдсан тэмтрүүлүүд агуйн хаалганд хүрч, нэг тэмтрүүл агуй руу орж байв. Гэндальф дээш гарсангүй. Хэрэв тэр хаалгыг хаах тарнийн үг санах гэж оролдсон бол тийм шаардлага байхгүй байсан нь тодорхой болов. Олзонд шунасан үй олон аймшигт амьтан хаалганаас шүүрэн авч, аюумшигт хүчээр угз тагтал хаалга тасхийн хаагдав. Агуй тас харанхуй болж, хаалганд хавчуулагдан тас хяргагдсан нэг тэмтрүүл бүдэгхэн харагдаад, гаднаас пижигнүүлэн нүдэх дуулдав.

Фродогийн дэргэд зогсч байсан Сэм мэгшин уйлаад хүйтэн гишгүүр дээр суучихав.

- Хөөрхий Билл, хар хэрээнүүд, цасан шуурга, чонодолоохууд, хуруутай тэмтрүүлүүд... - энэ бүхнийг хэн тэсч гарах юм бэ? Би түүнд юугаар ч тусалж чадсангүй, үнэхээр надад сонголт тулгарсан. Нэг бол Биллийн араас гүйх, эсвэл эзэнтэйгээ агуйд орох хоёрхон сонголт байсан. Мэдээж би эзэнтэйгээ явалгүй яах билээ.

Энэ үеэр Гэндальф хаалган дээр ирээд шидэт очроороо дэлдтэл хоромхон зуурт нүд гялбам гэрэл агуйг дүүргэж, нижигнэсэн их нүргээн сонсон, хадан шал доргисон боловч хаалга хаалттай хэвээр байлаа.

- Тийм юм байна гэж Гэндальф хэлээд – Хаалга нээгддэггүй юм байна. Одоо бидэнд ганцхан зам бий. Дорно зүг явах ёстой. Энэ хачин тэмтрүүлтнүүд эльфүүдийн царс моднуудаар хаалгыг нээх гэж оролдоод нуранги үүсгэсэн байна. Хайран сайхан царснууд – хэмээн харамсав.

- Сувгаар гарахад надад маш аймшигтай байсан. Бид гай зовлонд унаж байна гэж би мэдсэн.

Хаалганы дэргэд над руу ямар амьтан дайрсан бэ? Тэд нар олуулаа байсан уу? – гэж Фродо асуув.

- Би ийм амьтадтай нэг ч удаа тааралдаж байгаагүй. Гэвч тэр олон гарыг нэг л хар шидийн хүч удирдаад байна. Хэн нэгэн газар дорх гүний уснаас гарч ирсэн, эсвэл хөөгдсөн. Тэнд орхууд, чонодолоохуудаас хавьгүй аймшигтай эртний мангаснууд олон байдаг – гэж шидтэн хэлсэн боловч ёроолгүй гүний мангаснууд чухамдаа Фродог л отоож байжээ гэж бодсоноо хэлсэнгүй.

- Мангас л дугааж гэнэ. Би энэ ёроолгүй хар нүх рүү орохыг эсэргүүцэж байсан. Одоо эндээс биднийг хэн гаргах юм бэ? – гэж Боромир хамар дороо сөөнгөтөн хэлэв. Тэр энэ үгээ зөвхөн өөртөө хэлсэн боловч агуйн бөглүү цуурай түүний үгийг тод сонсожээ....

- Би, бас Гимли – гэж Гэндальф хэлээд – Ингэхэд бид замдаа гарах цаг боллоо – гэж хэлэнгээ шидэт очроо өргөн цэнхэр туяа татуулж шатаар өгсөв. Шат эгц бөгөөд өргөн байлаа. Аянчид хоёр зуун гишгүүр тоолоод дараа нь нууцлаг алс руу хөтөлсөн хонгилыг харав.

- Хоолоо идэцгээе, Мориид сандал олдохгүй биз, энд шатны гишгүүр байгаа болохоор сууж байгаад хооллож болно – гэж Фродо хэлэв. Түүний айдас алга болж, маш их өлсч байгаагаа мэдэв.

Тэд шатан дээр суун хооллоод дараа нь бүгд гурав дахь удаагаа анагуур хэмээх ундаанаасаа балгацгаав.

- Анагуур маш бага үлдсэн, гэвч бид хүч тамираа сэргээх нь чухал байлаа – гэж шидтэн дашмагаа далд хийх зуураа өгүүлээд – усаа ч гэсэн хэмнэх хэрэгтэй. Мориид олон булаг, шанд байдаг боловч агуйн усыг ууж болохгүй. Бид Мориин агуйгаас гарах хүртлээ ус авч чадахгүй - гэлээ.

- Хэр удаан явах вэ? - гэж Фродо асуухад:

- Гурав юм уу, дөрөв хоног. Ямар нэг гай тохиолдохгүй бол шүү дээ. Баруун хаалганаас зүүн хаалга хүртэл шууд явбал дөчин лиг байдаг юм. Гэхдээ энд шууд зам гэж байхгүй – гэв.

Хадгалагчид үүргэвчээ янзалж үүрээд, Гэндальфын араас даган харанхуй хонгилоор явлаа. Бүгд л Хар гол хүрч, аль болохоор түргэн газар дээр ил гарахыг хүсч байсан учир ядарсандаа хөл нь гуйвж байсан ч амралтгүй явна гэж шийдсэн байлаа. Гэндальф цуваагаа ээлжгүй тэргүүлэн явна. Зүүн гартаа шидэт очроо барьж, бусдаасаа гурван алхмаар түрүүлэн хонгилын харанхуйд гэгээ гарган, баруун гартаа Яррист илдээ барьж явав. Түүнтэй зэрэгцэн эцэж цуцашгүй Гимли, түүний араас Фродо Терн илдээ сугалан барьж явлаа. Терн, Яррист хоёр гэрэлтэхгүй байгааг бодоход орхууд ойрхон байхгүйн шинж, учир нь анхдагч эринд эльфүүдийн бүтээсэн илд ойр хавьд орх байвал түгшүүр зарлан гэрэлтдэг ажээ. Фродогийн араас үнэнч зарц Сэм, тэгээд Мерри, Пин хоёр, араас нь Леголас, Боромир алхаж, араас нь дуу цөөт Арагорн хамгаалж явлаа.

Хоёр гурван эргэлтийн дараа аянчид налуу руу бууж яваагаа анзаарсан бөгөөд удалгүй айхтар

халууцаж эхэлсэн боловч бүгчимдсэнгүй, заримдаа нүүр рүү нь сэрүүхэн агаар сэвэлзэж байв. Агуй руу уулын сэрүүн агаар ордог ажээ. Шидэт очрын гэрэлд Фродо байн байн хонгилын салаануудыг харж байсан бөгөөд тэдгээр салаанууд дээшээ, доошоо шаттай байв. Шидтэн юугаар баримжаалж яваа юм бол гэж Фродо сониучирхан ажиглаж явав.

Гимли Гэндальфт гол нь ялалтад итгэсэн итгэлээрээ тусалж байсан ба шидтэн өөрөө чиглэлээ тодорхойлж, хааяа нэг түүнтэй зөвлөлдөж байв. Глоины хүү Гимли уулын гномуудын удам боловч Мориин агуйн схемийн учрыг олохгүй л байв. Шидтэн ч гэсэн мэдрэмжээрээ баримжаалж явсан бөгөөд урьд нь Траиныг хайж явахдаа зүүнээс баруун тийш Мориинг гаталж байсан бол одоо эсрэг зүгт явж байгаа ч гэсэн чиглэлээ алдалгүй тодорхойлж байв. Түүний мэдрэмж нэг ч удаа алдаж байгаагүй билээ.

Гэндальф хонгилын нэг салаан дээр ирээд зогсч, Гимлитэй ердийнхөөсөө удаан зөвлөлдөхөд аянчид битүүхэндээ сандарсан боловч Арагорн: - Санаа бүү зов – гэж хэлэв.

- Айх хэрэггүй, Би түүнтэй хамт явж байхдаа хүнд байдалд нэг бус удаа орж байсан ч тэр ямагт гарах зам олдог байсан, энэ байтугай бэрх аялалд олон удаа явж байсан тухайг нь би эльфүүдээс сонссон. Бид түүнийг дагаж Мориинд ирсэн, тэр өөрт нь юу ч тохиолдлоо гэсэн биднийг эндээс гаргана. Тэр харанхуйд замаа олохдоо хатан хаан Берутиэлийн муурнаас ч илүү - гэж Арагорн ярив.

Тийм газарчин хадгалагчид аврал болж байлаа. Тэд Морийн хаалгын дэргэд сандарч байгаад бамбар бэлтгэж амжаагүй ба гэрэлгүйгээр цааш явах боломжгүй байв. Нэгдүгээрт, хонгил байнга салаалж байсан, хоёрдугаарт, замд нь горхи, гүнзгий худаг, өргөн ганга тааралдаж байсан бөгөөд гурван алхам орчим өргөн ёроолгүй мэт гүн нэг ганга тааралдахад тэд харайж гарсан ба Пинийг арай гэж харайлгажээ.

- Олс, хэрэг болно гэж би мэдээд байсан юм – Сэм өөрийгөө зэмлэж байв. Байсхийгээд л ганга тааралдах тул тэд тун ч удаан урагшилж байлаа.

Уруу зам эцэс төгсгөлгүй мэт санагдана. Ядарсандаа хөл нь гуйвж байсан ч амрахыг хэн ч хүсэхгүй байлаа. Фродо дахиад л түгшиж эхлэв. Тэмтрүүлнүүдээс аврагдаж, анагуур балгасны дараа бүрэн тайвширсан юм шиг байснаа одоо юунаас ч юм бүү мэд айж эхлэв. Тэрбээр Эргүүлэг уулан дээр хар морьтны илдэнд шархдаад бүрэн эдгэрсэн боловч тэр шарх ул мөргүй алга болоогүй ажээ. Тэр орчныг тун соргог мэдрэх болсон ба бусдынхаа анзаараагүй юмыг заавал түрүүлж мэдрэдэг болсон байв.

Тэр харанхуйд бусдаас сайн харж, аюул ойртсоныг итгэлтэй мэдэрч байлаа. Шидтэн түүнээс олон хувь алс харж байсан боловч гол хадгалагч тэрбээр эргэн тойронд дайсан байгааг мэдэрч байлаа. Бөгж түүний хүзүүнд хүйтэн, хүнд, аюултай ачаа болж, урд нь үл үзэгдэх олон дайсан отоож, араас нь нэг дайсан дагаж байгааг мэдэрч байлаа. Гэвч Фродо түгшүүр зарласангүй, тэр нөхөддөө өөрөөсөө илүү итгэж байсан боловч Терн илднийхээ бариулыг чанга атган, Гимли, Гэндальф хоёроос хоцрохгүйг хичээж явлаа. Шидтэн энэ аюулыг мэдэж байгаа болов уу? – гэж тэр бодно...

Хадгалагчид хоорондоо бараг ярилцахгүй, хааяа нэг дуулдах төдий шивнэн ярилцаж байв.

Хонгил дахь нам гүмийг зөвхөн болгоомжтой алхах хөлийн чимээ л эвдэх бөгөөд Гэндальф замаа сонгохоор зогсоход бусад нь бас зогсч, хонгилд зөвхөн агуйн усны шоржигнох чимээ л сонсдоно. Гэвч Фродоусны шоржигноонтой адилгүй нэг чимээ сонсогдсоор нэлээд удав. Тэр бол нүцгэн хөлийн хурдан хурдан гишгэх чимээтэй төстэй дөнгөж сондсох төдий чимээ байв. Тэднийг зогсоход тэр чимээ хэсэг үргэлжлээд зогсдог байв.

Үнэхээр сонсогдож эхлэв үү, эсвэл тэгэж сонсогдов уу? Агуй дахь горхины хоржигнооноос огт өөр нэгэн чимээ аргагүй л ялгарч сонсогдоно. Энэ нь шаламгай нүцгэн хөлөөр болгоомжтойёо газар алгадах чимээг санагдуулж байв. Гэнэт тэр чимээ тасалдаж, гэхдээ огцом алга болсонгүй, цуурай мэт бүгдхэн давтагдсаар, Сахиулсанууд өөрсдөө тийн гайхан зогсоцгоох мэт байвай.

Шөнө дунд аянчид гурван салаа хонгилын уулзварт тулж Гэндальф бодол болон зогсов. Гурван хонгил гурвуулаа дорно зүг рүү чиглэсэн боловч зүүн талынх нь доош бууж, дундах нь чигээрээ үргэлжилсэн ба баруун талынх нь арай дээш өгссөн байв.

- Үгүй ээ, би энэ газрыг санахгүй байна. Ёстой санахгүй байна – гэж шидтэн хүлээн зөвшөөрөв. Хонгилын дээр сонголт хийхэд тус болох ямар нэг тэмдэг байгаа болов уу гэж бодоод очроо дээш өргөж харсан боловч ямар ч тэмдэг байсангүй.

- Би хаашаа явахаа мэдэхээ байтлаа ядарсан юм байлгүй дээ. Та нар ч гэсэн амрахад илүүдэхгүй гэж бодож байна. Өглөө болтол азная... Өглөө боллоо гээд гэгээ орохгүй ч гэсэн яая гэхэв. Ямар ч гэсэн өглөө оройноос цэцэн гэдэг.

Том хонгилын хойт хананд чулуун хаалга байхыг аянчид харав. Гэндальф хаалганд тулж очоод хажуу талд нь зогсч, аяархан түлхвэл хаалга нээгдлээ.

- Хойшоо! – гэж шидтэн зандрав. Учир нь Мерри, Пин хоёр хонгилын хүйтэн хадан шалан дээр биш, тохитой газар тайван амрах нь гэж баярлаад шууд ухасхийн орох гэсэн ажээ. – Хойшоо бай! – гэхэд нь хоббитууд арагш ухрав.

- Бид энд юу байгааг мэдэхгүй, энэ хаалгаар хаашаа юу руу ордгийг мэдэхгүй, би эхэлж орно – гээд Гэндальф дотогш орж, очроороо гэрэлтүүлж харвал намхан таазтай жижигхэн тасалгаа байлаа.

- Харж байна уу? – гэж шидтэн тасалгааны дунд байгаа харанхуй хар нүх рүү заав. Нүхний ирмэг дээр зэвэрсэн гинж, хагархай чулуун таглаа байлаа.

- Та хоёрыг Гэндальф зогсоогоогүй бол энэ нүх рүү унах байсан, та хоёрыг худгийн ёроолд хэзээ хүрэх бол гэж таах хэрэг ч гарч магадгүй байсан, аз болоход бид туршлагатай удирдагчтай явж байна, хэрэггүй юм руу ухасхийх хэрэггүй - хэмээн Арагорн Мерри, Пин хоёрыг зэмлэв.

- Энэ бол харуулын байр. Энд харуулууд өдөр шөнөгүй сууж, гурван хонгилын үүдийг манадаг байсан юм. Худгийн амыг чулуун тагаар тагладаг байж, маш их гүнзгий байх – гээд Гимли хоббитууд руу мушилзан харав.

Худаг Пиний анхаарлыг татаад болж өгсөнгүй. Нөхөд нь худгаас аль болохоор хол тухалж байх хооронд Пин худгийн ам руу мөлхөж очоод, айдсаа даран байж өнгийж харав. Урдаас нь сэрүүхэн чийг татав. Юу хүсээд байгаага мэдэлгүй тэр нэг чулуу тэмтэрч аваад худаг руу шидэж, амьсгаа даран чагнав. Чулуу дэндүү удаан унаж байсан тул амьсгаа авахаас арга байсангүй, хэд хэдэн удаа амьсгаа авсны эцэст бүүр хол ус цүлхийх чимээ бүдэгхэн сонсдоход худгийн цуурай тэр чимээг олон дахин давтлаа.

- Юу вэ - хэмээн Гэндальф болгоомжлоход Пин үнэнээ хэлэв. Шидтэн тайвширсан боловч түүнийг зандарч - Бид тэнэг хоббитуудыг зугаалуулж яваа биш, дараачийн удаа уйдаад байвал өөрөө худаг руу үсрээрэй, бид хүний үг авдаггүй нэг тэнэг гайгаас сална биз. Харин одоо чимээгүй суу – гэв.

Гэндальф чих тавин чагнахад эргэн тойрон чимээгүй байснаа худгийн харанхуй гүнээс түг-түг –түг хийтэл тогших чимээ сонсдож, түүнийг цуурай давтлаа. Цуурай намдахад дахиад таг-түг-таг гэж хэн нэгэн дохио өгч байгаа юм шиг хачин тогшилт үргэлжлэв. Тогшилт чимээгүй болоход Гэндальфын очир үл мэдэг гэрэлтэв.

- Алхны чимээ л байна даа, эсвэл би юу ч мэдэхээ больсон байх – гэж Гимли хэлэв.

- Чиний зөв байх аа – Энэ огт сайны ёр биш. Пиний чулуу энд хамаагүй, гэхдээ л энэ тэнэг үйлдэл ямар ч гай тарьж болно. Ийм юм дахиад яасан ч хийж болохгүй!.. Одоо Пинээс бусад нь унтацгаа, Пин нүглээ цайруулж харуулд гар. Сайхан амарцгаагаарай.

Пин үг ч дуугаралгүй хаалга руу очиж суув. Харуулын өрөөнд таг харанхуй болж, Гэндальфын очир унтрав. Пин худагнаас нүд салгасангүй, газар доорх мангас юу юугүй гараад ирэх гэж байгаа юм шиг санагдана. Юугаар ч хамаагүй худгийг таглах юмсан гэж маш их хүсэвч ойртож чадсангүй. Ашгүй Гэндальф унтаж байх шиг байна...

Гэвч Гэндальф унтаагүй байв. Морийд өчүүхэн төдий алдаа гаргавал бүгдээрээ сөнөх учир замаа зөв сонгохын тулд тэр өмнөх аяллаа нэгд нэггүй сэргээн санахыг хичээж байв. Цагийн дараа шидтэн Пиний дэргэд ирж:

- Очиж унт. Миний нойр тэртэй тэргүй хүрэхгүй. Зүгээр сууснаас харуулд гаръя. Маргааш бидэнд амаргүй өдөр болно – гэлээ.

- Яагаад юм бодоход хэцүү байгааг би мэдлээ, тамхи сороогүй их удсан байна шүү дээ, Хүрэн хаалганы дайралтаас өмнө л нэг татсан даа – гэж тэр өөртөө үглээд хаалганы дэргэд суув.

Пин унтахаасаа өмнө хамгийн сүүлд харсан зүйл нь гаансаа амандаа зуусан шидтэний тамхины гал, түүний хуруу болон унжуу хамрынх нь үзүүр байлаа. Өглөө нь Гэндальф аянчдыг сэрээв. Тэд цөм сайхан унтаж амарсан бол шидтэн шөнөжин сууж хоножээ.

- Би хаашаа явахаа шийдчихлээ. Дунд хонгил дэндүү нарийн учир хаалга хүрэхгүй. Хаалга хүрэх хонгил өргөн байх ёстой. Зүүн хонгил халуун, бүгчим учир доошоо явсан байж таарна. Бид баруун хонгилоор дээшээ явна.

Хадгалагчид хоёрхон удаа түр амсхийгээд найман цаг болж байхад дээш гарлаа. Санаа зовоох юм огт үзэгдсэнгүй, зам заагч гэрэлт од мэт шидэт очрын гэрэл тэднийг ёроолгүй хар нүхнээс цуцалтгүй хөтлөн явсаар байлаа. Хонгилын хана улам л холдож, тааз нь үзэгдэхээ болино, хөл доор чулуун хавтан шал гарч ирлээ. Аянчид өргөн тавцан дээр гарч ирэхэд элдэв хонхор юм уу нүх байсангүй, хонгил нэг ч удаа салаалаагүй учир тэд өмнөхөөс хавьгүй хурдан урагшилж байв.

Шулуун явахад арван таваас арван найман лиг алхана гэж Гэндальф тооцоолж байсан боловч хорь гучин лиг явах бололтой. Хонгил улам л өгсүүр болж байсан тул Фродогийн сэтгэл арай өөдрөг болж байсан ч нүцгэн хөлийн улын чимээ сонсогдсоор л, эсвэл бодогдсоор л байлаа.

Хадгалагчид хичнээн ядарч байсан ч шургуу урагшилсаар гэнэтхэн уудам харанхуй орон зайд яваад орчихов. Тэд хонгилоос гараад хязгааргүй мэт том, сэрүүхэн агуйд ороод иржээ. Аянчид сэтгэл догдлон Гэндальфыг тойрч зогсов. Ар нуруунаас дулаан салхи үлээж, агуйн агаар гайхалтай цэнгэг байлаа.

- За ингээд бид амьдралтай агуйд ороод ирсэн шиг байна! - гэж Гэндальф баяртай хэлээд – тэгэхлээр би зөв зам сонгожээ. Хэрэв би андуураагүй бол бид одоо Зүүн хаалганаас дээгүүр байна, эндээс нэлээд яваад бид гэрэлд гарах байх.

Гэндальф шидэт очроо өргөхөд агуйд нүд гялбам гэрэл цацрав. Аянчид өндөр хүнхэр таазтай, толь мэт өнгөлсөн хар ханатай, дөрвөн өргөн нуман гарцтай асар том танхимд зогсч байв. Очир гэнэт ассан шигээ гэнэт унтрав.

- Тийм ээ, бид амьдралтай агуйд ороод ирсэн байна. Сууцыг гэрэлтүүлэхийн тулд хананд нь олон цонх гаргасан байгаа, одоо харанхуй шөнө учир бид харахгүй байна. Өнөөдөр цааш явах хэрэггүй, бид бүгдээрээ ядарсан, хөөрхий хоббитууд хөл дээрээ ч тогтож чадахгүй шахам байна. Би эндүүрээгүй бол маргааш өглөө бид гэрэлтэйд босно. Одоо унтацгаая. Маргааш бид амарч, тэнхэрсэн байх ёстой. Одоохондоо бидэнд дандаа аз тохиож, замын ихэнх хэсгийг туулчихлаа.... гэхдээ бид Мориингоос хараахан гараагүй, Дорно хаалга тэртээ холд байна.

Хадгалагчид танхимын баруун хэсэгт тухлан хөнжлөө нөмрөөд хэвтээд өглөө. Тэнд арай дулаахан байлаа. Хоббитуудад хачин мэдрэмж төрж байв. Тэд төгсгөлгүй олон харанхуй хонгилуудын дунд төөрч, гарах гэж оролдовч хязгааргүй харанхуйн далайд ороод байгаа мэт санагдана. Мориин тухай хамгийн аймшигтай домог ч ийм байгаагүй мэт. Гэтэл тэдэнд ямар ч муу юм тохиолдоогүй, аз ивээж байна гэж Гэндальф хэлсэн...

- Гномууд ч мундаг юм аа! – Ийм аварга агуй, хонгил яаж нүхэлддэг байна аа! Лав тоолшгүй олон ажилчин байсан байх. Яах гэж энэ вэ? Харанхуйд амьдарч болно гэж үү? Энд амьдардаггүй байсан байх аа? – гэж Сэм аяархан өгүүлэв.

- Амьдардаггүй гэдэг чинь юу гэсэн үг вэ? Энд Морийн хаант улс байсан юм. Энд тэндгүй хурц гэрэл асч, Мориин орон Дундад газарт алдаршиж байсан юм. Энэ тухай манай домгуудад өгүүлдэг юм – гэж гном баатар гоморхов.

Гимли хөнжлөө хуулж хаяад ухасхийн босч бөглүү цуурайн дор:

Энэ ертөнц унтаж байхад

Эхний гном агуу Дарин

Эцсийн зүүдээ сэгсэрч хаяад

Энэ орныг анх харжээ.

Өлгий болсон ханан хясаанд

Өндөрт мандсан сарны туяанд

Нэрээ ч олоогүй шинэ

Нэгэн ертөнц нээгджээ.

Дарин тэр оронд нэр өгчээ:

Гол горхи, уул тал,

Намаг, хавцал,

Нуур цөөрөм,

Нэртэй болмогц

Амьдрал цогцолжээ;

Тодхон зүүдэнд үзэх адил

Толь мэт усны мандалд

Титэм одод гялалзуулсан

Тэнгэрийг бас харжээ.

Ихэр нуурын хөвөөнд

Идэр хааныг залжээ.

Тэгээд хаан ширээг

Тэндээс Мориид урьжээ.

Мөнгөн титэмт танхим

Мөнхийн гэрлээр гийж

Түнэр шөнийн харанхуй ч,

Түнэл хорон манан ч

Тийшээ нэвтэрч чадаагүй.

Оргил уулсын доогуур

Очлох гэрэл жигүүр дэлгэн

Айдас, зовлонг мэдэхгүй

Ард түмэн хөдөлмөрлөж байлаа.

Аялгуу дуу цуурайлж байлаа.

Асар гүн ёроолоос

Алт эрдэнэс олборлож байлаа.

Уулан доор аюумшигт мангас

Унтаж байсныг тэд мэдсэнгүй,

Хөгжөөнт дуугаа дуулж,

Хурц зэвсгээ давгаж байлаа.

Хадан мангас нойроос сэрж

Харанхуй сүүдэр нөмрөхөд

Хөөн хар нуур мэлтийж,

Хөлгүй их гүнд нь

Хөх тэнгэр хөмөрчээ.

- Ёстой мундаг! – гэж Сэм бахдан дуу алдаад – Би таны энэ домгийг цээжлэх хэрэгтэй юм байна. Гэвч энэ домгийг сонсохоор эндхийн харанхуй улам ч харанхуйлах юм байна, алмаазнууд нь одоо байгаа болов уу?

Гимли дуугарсангүй. Домгоо уншиж гүйцээд тэр ярих дургүй байлаа.

- Алмаазууд гэнэ ээ? - хэмээн Гэндальф асуугаад – Тэр эрдэнэсүүд үлдээгүй, ямар ч гэсэн энд байхгүй. Аль дивангарын эрт цагт орхууд аваад алга болсон. Гэхдээ доод давхрууд, уурхайнууд, агуулахуудад хамгийн шуналтай орхууд ч ордоггүй, тэнд эртний аймшиг орогнож байгаа.

- Балин яах гэж Морийд эргэж очсон юм бол? – гэж хэрэгт дуртай Сэм асуув.

- Домогт мифрил авах гэж. Тэр бол гномуудын ажлын материал, төмөр ч биш, алт, алмааз ч биш. Гномуудад эд баялаг, алдар суу авчирсан жинхэнэ Мориин мөнгийг эльфүүд мифрил гэдэг юм. Тэр цагт Мориин мөнгө алтнаас арав дахин үнэтэй байсан. Харин одоо бол Дундад газарт ерөөсөө байхгүй учир жинхэнэ үнэлж барахгүй их үнэтэй. Мориин мөнгөний судал хамгийн гүний давхаргад байдаг, уулан доогуур яваад Хүрэн эвэр хүрдэг, тэнд хүрэхийн аргагүй ёроолгүй гүн байдаг юм. Мифрил гномуудыг баяжуулж алдаршуулсан боловч түүнээс бүх гай зовлон үүдсэн юм. Учир нь тэд тэр баялгийг улам ихээр олборлох гэж газрын гүн рүү ороод Гүний айдас буюу Агуу Дариныг сэрээчихсэн юм. Гномууд Мориогоос зугтахад тэдний олсон мифрилиг орхууд эзэмшсэн, дараа нь түүний үнэ цэнийг мэдэхгүйн харгайгаар Хар эзэнд түүгээр татвар төлсөн.

Мифрил!.. Тэр бол Дундад газрын ард түмнүүдийн мөрөөдөл. Зэс шиг давтагдамтгай, ган шиг бат бөх, өнгөлөхөөр илд шиг гялалздаг, хэзээ ч өнгө нь бүдгэрдэггүй, гайхалтай хөнгөхөн. Эльфүүд мифрилиг маш их үнэлдэг. Тэдний эртний сүлд Феанорын одыг Морийн мөнгө, мифрилээр бүтээсэн юм. Та нар түүнийг Хаалган дээр харсан шүү дээ. Энүүхэндээ гэхэд Торин Бильбод мифрил хөө хуяг бэлэглэсэн юм шүү дээ. Одоо тэр хөө хуяг хаа байгаа нь сонин байна. Магадгүй нэг авдарт л хэвгэж байгаа байх даа....

- Мифрил хөө хуяг бэлэглэсэн гэж үү? - хэмээн Гимли гайхаж - Ёстой хааны бэлэг гэж тэрийг л хэлнэ дээ! – гэв.

- Чи зөв хэллээ - гэж Гэндальф тайвнаар батлаад – Энэ хөө хуяг бүх Хоббитаныг түүний оршин суугчид, ан амьтадтай нь нийлүүлснээс үнэтэй – гэв.

Фродо гараа цамцан дотуураа шургуулж, сэрүү оргисон хөө хуягаа илж суулаа. Тэр тэвчээр зааж, нөхдөдөө хөө хуягныхаа талаар юу ч хэлээгүй боловч Гэндальфын ярьсныг сонсоод гайхах, бишрэх хоёр зэрэгцэв. Миний хөө хуягийг худалдаж авья гэвэл Хоббитан орныг юутай хүйтэй нь өгөөд ч хүрэхгүй гэнэ ээ! Бильбо энэ тухай мэдэж байсан болов уу? Мэдэж л байсан даа! Тиймээ, Бильбо надад хааны бэлэг барьжээ. Гэвч Бильбо болон алс холын Хоббитан орныг санаад Фродо Уутан хясааны эдлэн, өргөөндөө амар жимэр суугаад Мориин орон, мифрил, гол нь бөгжний тухай юу ч мэдэхгүй байсан цагаа санах. Цагийг буцааж болдогсон болоосой!..

Тэгсгээд аянчид бүгдээрээ унтаж, Фродо хав харанхуйд ганцаараа үлдэв. Тэр харуулын үүргээ гүйцэтгэж байгаа. Тэр баруун хаалганд налж суугаад хонгил руу харж байв. Тэр хонгилоор Мориин гүнээс авирч гарсан аймшигт амьтан агуйд мөлхөн орж ирж байгаа юм шиг санагдаж, айдаст хүлэгдэн, духныхаа хүйтэн хөлсийг арчтал гар нь мөс шиг хүйтэн болсон байв. Хоёр цаг харуулд суухдаа тэр үхмэл нам гүмийг хичнээн чих тавин чагнасан ч ямар ч чимээ сонсогдсонгүй, ядаж нүцгэн хөлийн улын чимээ ч гарсангүй.

Тэгээд үүрэглэж эхэллээ. Харуулын хугацаа дуусч байх үеэр хонгил руу дахин хартал дөнгөж үзэгдэх төдий хоёр өчүүхэн гал агуй руу ойртож байх шиг. Тэр цочиж, нүдээ анивчаад толгойгоо сэгсэрч, харанхуй хонгил руу дахин харлаа. Нөгөө гал харагдсангүй. “Шившиг” - гэж тэр өөртөө хэлээд – “Би харуулын байран дээр унтсан байна” гэж бодлоо. Тэгээд босч,

Леголас харуулын халаа авах хүртэл суусангүй.

Хөнжлөө нөмрөнгүүт нам унтсан боловч нөгөөх нүцгэн хөлийн чимээ, хоёр жижиг гал агуй руу улам ойртоод байгааг зүүдлэх ч шиг, харах ч шиг... Цочин сэрвэл агуйд сааралдуу гэрэл орж, нөхөд нь аяархан ярилцаж байв.

- Өглөөний мэнд! - гэж Гэндальф түрүүлж мэндлээд – дэлхийд өглөө морилж, бидэнд сайн мэдээ дуулгаж байна. Бид Морийн эзэнт гүрний нутгийг туулаад байна, одоо Хар голын хөндий рүү орохын тулд орой болохоос өмнө Хаалганд хүрэх хэрэгтэй – гэлээ.

- Тэгвэл ч сайн л байна - гэж Гимли гүвтнээд –Харанхуйд ууссан агуу их Мориин ямар ч зоригтонг айдсаар хүлдэг. Ер нь Балин Мориид ирээгүй юм шиг байна, ирсэн бол ямар нэг ул мөр үлдээх л ёстой...

Гэндальф энэ өдөр амрахгүй гэж шийдэв:

- Бидэнд бүгдэд нь амралт хэрэгтэй байгаа, гэвч Толин нуур хүртэл хагас өдөр явна. Миний ойлгож байгаагаар бидний хэн ч гэсэн Мориид дахиад нэг шөнийг өнгөрөөх хүсэлгүй байгаа.

- Юу үнэн бэ, тэр үнэн- гэж Боромир бувтнаад – Бид хаашаа явах вэ? Дорно зүг рүү юу?

- Одоохондоо мэдэхгүй байна, миний бодлоор бид хойт Хаалганаас дээгүүр байгаа, тэр хаалга хүртэлх замыг олоход амаргүй. Эхлээд би эргэн тойрноо тайван харах хэрэгтэй байна. Хойт талын нуман хаалга хамгийн гэрэлтэй нь байна. Тэгэхээр хойт хонгил руу шагайгаад үзье. Хэрэв бид цонх хүртэл явж чадвал бид хаана байгаа нь тодорхой болно, хаашаа явахаа би шийднэ. Гэвч харамсалтай нь Мориин агуйн цонхнууд маш өндөрт байдаг юм – гэж Гэндальф ярив.

Хадгалагчид түргэн зуурт юмаа янзлаад Гэндальфын араас хойт хонгил руу хөдлөв. Хонгилын баруун талаас гэрэл тусч байв. Зуун тавин алхам яваад хонгил руу гэрэл оруулж буй хагас нээлттэй хаалга харлаа. Хаалганы цаана зүүн талдаа цонх гаргасан дөрвөлжин тасалгаа байлаа. Харанхуйд нүд дассан аянчид гэрэлд гялбаж, босгон дээр зогсов. Тэгээд тасалгаа руу болгоомжтой алхаж орлоо.

Хар саарал тоосонд хучигдсан ямар нэг хэврэгхэн хэлтэрхийнүүд дээгүүр алхаж, тасалгааны голд байгаа гурав дөрвөн алд өндөр дөрвөлжин чулуунд дөхөж очив. Таазны доорхи жижигхэн цонх тэрхүү том чулуун дээрх цагаан гантиг хавтанг гэрэлтүүлж байв.

- Энэ чинь арай булш биш биз дээ? – гэж Фродо хэлээд хавтанг цээрлэнгүй харав. Дэргэд нь Гэндальф ирж зогсов. Хавтан дээр хачин рун бичээс байлаа.

- Энэ бол эртний мориин хэл, энэ хэлээр хүмүүс болон гномууд ярьдаг –гээд

МОРИИН ХААН ФУНДИНЫ ХҮҮ БАЛИН – гэж уншив.

- Тэгэхлээр Балин нас барсан юм байна, - гэж Фродо хэлэв. Гимли юүдэнгээ нүүр рүүгээ буулгаад:

- Энэнээс л би айж байсан юм – гэж аяархан хэлэв.

Бүлэг 17

Морийн гүүр

Хадгалагчид булшны дэргэд дуугүй зогсов. Фродо Балиныг, Бильботой олон жил нөхөрлөж байсныг нь, аль эрт Хоббитанд ирснийг нь гуниглан санав. Тоосонд дарагдсан Морийн хадан агуйнаас тэр эрт цагийн энх амгалан амьдрал мартагдсан үлгэр мэт санагдана.

Гашуудаж дуусаад аянчид тоост тасалгааг нэгжиж, Балин болон түүний эрэлхэг баатруудын хувь заяаны төгсгөлтэй холбоотой ямар нэг ул мөр олохыг оролдов. Хонгил руу гарах хаалганы эсрэг талд, цонхны дор бас нэг хаалга байхыг тэд харлаа. Тэд өдрийн гэрэлд дасаад хөл дор нь байнга шажигнаад байсан хэврэгхэн хэлтэрхийнүүд нь амь үрэгдсэн дайчдын яс байсныг мэдэж, яснуудын дунд хар саарал тоосон дотор гном баатруудын байлдааны сүх, хэмхэрсэн дуулганууд, хагарсан бамбай, уулын орхуудын дуртай зэвсэг харлуулсан үзүүртэй тахир сэлэмнүүд хөглөрч байхыг үзэв.

Нэг буланд зэвэрсэн төмөр бүслүүртэй хэмхэрхий авдрууд байв. Нэг авдарт нь уранхай ном байхыг Гэндальф харлаа. Номны зах нь түлэгдсэн, илдээр сийчиж, цусны хүрэн толбонд будагдсан байв. Гэндальф номыг болгоомжтой авч, Балины булшин дээр тавилаа. Фродо, Гимли хоёр шидтэний дэргэд ирж, эльф, доль, морий хэлээр бичсэн хуудсуудыг нь хэрхэн нямбайлан эргүүлж байгааг харж зогсов. Номын хуудсууд нимгэн ясан ялтас шиг хатуу мөртөө хэврэгхэн байлаа.

- Миний ойлгож байгаагаар энэ бол Балины аян замын тэмдэглэл байна. Үүнийг гучин жилийн тэртээ Балины дайчид хар голд орсон өдрөөс эхэлжээ. Энд 1/3 гэж бичсэнийг харж байна уу? Миний бодож байгаагаар энэ бол нэгдүгээр он, гуравдугаар хуудас гэсэн үг. Номын эхний хоёр хуудас алга байна. Би эндээс ийм юм олж мэдлээ:

“Бид хаалганы дэргэд орхуудын харуулуудыг устгалаа. Хар... цаашаа унших боломжгүй, цусанд будагдсан байна, гэхдээ мэдээж харуулын тасалгаа гэсэн үг байж таарна. Харуулууд түгшүүр зарлаж амжсан учир... бид Толин нуурын эрэгт маш олон орхыг устгасан. Флоин дайсны бүхэл бүтэн отрядыг тас хяргасан боловч өөрөө дайсны сумнаас үхлийн шарх авсан...” Хоёр мөр унших боломжгүй байна. Цааш нь: ... бид хойт жигүүрийн хорин нэгдүгээр цамхгаас орхуудыг, хөөж гаргалаа. Энд ... дахиад гаргагдахгүй байна, гэхдээ уурхай гэсэн үг байна. Эцэст нь: ... Балин дайчидтайгаа түүх бичлэгийн өргөөнд байрлалаа....

- Энэ бол түүх бичлэгийн өргөө юм байна – гэж Гимли хэмхэрхий авдарнуудыг харангаа хэлэв.

- Цааш нь хэдэн хуудас цусанд будагдаж гаргагдахгүй болсон байна, би зөвхөн алт, даринь сүх, дуулга хоёр гэсэн үг л гаргаж уншлаа. Дараа нь: ... Балин өөрийгөө Мориин улсын хаан гэж зарлалаа. Ингээд эхний хэсэг дуусч, гурван од тавиад өөр хүний бичиг байна: Бид жинхэнэ мөнгийг оллоо.... дахиад гаргагдахгүй байна, харин сүүлээсээ хоёр дахь мөрөнд: ... Ойн гурав дахь гүний давхаргад байгаа зэвсгийн агуулах руу явлаа... – дахиад гаргагдахгүй байна - ... баруун зүг рүү ... – гээд энд жадны үзүүр хатгасан байна... тэгээд Эльфийн

Хаалганд – гэж байна.

Гендальф тэрхүү түүхийн хуудсуудыг дуугүй эргүүлж сууснаа:

- Хэдэн хуудас маш их гэмтсэн байна, ийм муу гэрэлд унших боломж алга, -гэснээ хэсэг дуугүй харж байгаад нөхдөдөө хандаж: - Их яарч бичсэн байна, өөр өөр хүмүүс бичжээ. Хэдэн хуудас нь огт алга, тэгээд дараачийн хуудас нь V гэсэн тэмдэгтэй – аянд гарснаас хойш тав дахь жил, V/1, V/2, V/3, V/4... Ойлгогдох юм алга аа, харин энэ юу вэ? Аа, энд овоо гаргацтай боловч яагаад ч юм эльф хэлээр бичсэн байна.

Гимли булшны дээрээс өнгийж, Гендальфын хажуугаар түүх бичиг рүү хараад:

- Энэ бол Орийн бичиг байна, тэр чухал мэдээллийг эльфээр бичдэг гэж би сонссон гэхэд шидтэн:

- Энэ чухал мэдээ тун ч гунигтай байх вий гэхээс айж байна. Хамгийн эхний үг нь “гашуудал” гэсэн үг байна. Цааш нь уншигдахгүй юм... дөр гэдэг нь лав өчигдөр гэсэн үг. Тийм байна: ... Өчигдөр, 10-р сарын 10-нд Мориин хаан Балин нас барлаа. Тэр Толин нуур руу бууж явахад нь хясаанд нуугдан отож байсан орх харвалаа. Хааны нөхөд тэр орхыг устгасан боловч үй олон дайсан дайрлаа... энэ хуудасны төгсгөл нь алга,... дараачийн хуудас нь Мөнгөлөг голоор зүүн талаас... гэж эхэлжээ. Дахиад хатсан цус байна, дараа нь: ... Хаалгыг хааж амжлаа... цааш нь уранхай, сумаар харвасан юм шиг байна, тэгээд хэдэн үг байна:

... хэрэв... бол хаалгыг хамгаалж чадах байлаа. Энэ хуудасны доод тал түлэгдсэн байна... ганцхан “аймшгийн” гэсэн үг үлджээ.

Балин л харамсалтай амь үрэгдэж дээ. Тэр үнэхээр эрэлхэг дайчин, мэргэн удирдагч байсан юм. Түүний хаанчлал ердөө таван жил үргэлжилжээ. Түүхэн бичиг энд тасарсан байна, алга болсон хуудаснуудыг эрж хайх цаг бидэнд алга, Балины нөхөд яасныг мэдэх арга бидэнд алга.

Тийм ээ, энэ тун ч гунигтай түүх байна, - түүний нөхөд бас л амь үрэгдэцгээжээ... Ингэж байна:... Бидэнд ухрах газар алга. Хаашаа ч! Дайснууд харуулын цамхаг, гүүр хоёрыг эзэлсэн. Лони, Фрар, Ноли нар уналаа... Энд зургаа, долоон хуудас цусанд будагдсан байна, тэгээд Баруун хаалганы тухай өгүүлжээ: Садар гол хөндийг үерт автуулсан. Ус хаалганд тулж ирлээ. Гүний манаач Оиныг живүүллээ. Бидэнд ухрах газар алга. Хаашаа ч!.. энэ хуудасны доод тал алга байна – гээд шидтэн хэсэг бодолд автсанаа - Аа, бас нэг хуудас – гээд шалан дээрээс үнгэлдсэн ганц хуудас авч: ... Бидэнд ухрах газар алга. Хаашаа ч! Дайснууд гүний давхраас Үхлийг дуудаж ирлээ! Тээр доор хаа нэгтээ аюумшигт нүргээн болж, хөл дорх газар алга боллоо. Тэд ирж байна!.. Энэ бол түүх бичгийн эцсийн өгүүлбэр... Ингээд түүх бичлэг дуусч байна. Сүүлчийн түүх бичигч юун тухай өгүүлснийг ойлгох юмсан – гээд шидтэн дуугүй болж бодлогошров.

- “Бидэнд ухрах газар алга. Хаашаа ч! - гэж Гимли амандаа хэлэв. Тэд булшинд орж ирснээ гэнэт мэдэж, бүгдээрээ, Гендальф хүртэл цочирдон мэгдэв.

- Тэд хоёр фронтод тулалдсан байна - гэж Гендальф нам гүм байдлыг эвдээд – Тэд зүүн,

баруун хоёр хаалгыг хамгаалж байжээ. Тэдэн рүү чухам ямар дайсан довтолсныг мэдэх юмсан. Баатарлаг боловч ухаангүй оролдлого бүтсэнгүй. Балин болон түүний нөхөд бүгд амиа алджээ... Одоо бид эндээс явах цаг боллоо. Гимли, Балины түүхэн бичгийг ав, үүнийг Дайнд өгөх хэрэгтэй, эрэлхэг Балин минь, тайван нойрс доо, Мориин орон чамайг үүрд авч үлдлээ!.. Явцгаая, бидний зам амаргүй шүү.

- Одоо бид хаашаа явах юм бэ? - гэж Боромир асуув.

- Эхлээд арагшаа буцна. Гэхдээ бид цагийг дэмий хоосон өнгөрөөгөөгүй. Энэ булш бол хуучин түүх бичлэгийн өргөө байсан газар, тэгэхээр бид хаана байгааг би мэдэж байна. Умард жигүүрийн долоо дахь давхарт байна. Одоо бид буцаж Гонхот танхим руу орно, гномууд түүнийг хориннэгдүгээр өргөө гэж нэрлэдэг байсан юм, тэгээд зүүн хонгилоор доош бууж, өмнө зүг рүү эргээд Хаалганд хүрнэ. Замдаа! – гээд Гэндальф түрүүлэн алхав...

... Яг тэгтэл Мориин гүнээс - P-P-P-P-0-K, - гэсэн нүсэр нүргээн нижигнэн дуулдаж, хөл дорх чулуун шал доргин чичрэв.

Аянчид үг дуугүй хаалга руу ухасхийв. P-P-PP-0-K – гэсэн аймшигт нүргээн Мориин агуйнуудаар дахин нүргэлж, дахиад хэдэн удаа P-P-P-P-0-K, P-P-P-P-0-K, P-P-P-P-0-K, P-P-P-P-0-K – хэмээн Мориин хязгааргүй гүнийг хэн нэгэн аварга том бөмбөр болгосон юм шиг нижигнэж байлаа. Тэр нүргээнд хариу өгч байгаа юм шиг хаа нэгтээ ойрхон газраас эвэр бүрээ тасхийн, үй олон хүнд хөлийн чимээ сонсдов.

- Орхууд! - гэж Гимли хашгирлаа.

- Тэд ойртож байна- гэж Леголас хашгирлаа.

- Отоонд орчихжээ, бид нэгэн цагт Балины нөхөд баригдсан шиг баригдаж байна. Гэхдээ тэдэнтэй би хамт байгаагүй, юу болохыг үзнэ дээ – гэж шидтэн тайван хэлэв...

Мориин орон p-p-p-p-0-K, P-P-P-P-0-K – хэмээн нүргэлсээр, агуйн хана илэрхий доргин чичирнэ.

- Зүүн хаалгыг түгжих гээд үз! - гэж Арагорн хашгираад илдээ сугалав: - Гонхот танхимд орох хэрэгтэй! Боромир бид хоёр түрүүлж явна.

- Бүү яар, - гэж Гэндальф түүнийг зогсоогоод – Одоохондоо бид зодоон эхлэх шаардлагагүй. Зүүн хаалгаар ухаръя - гэлээ.

Эвэр бүрээ дахин тасхийж, үй олон хөлийн чимээ улам ойртов. Хадгалагчид бүгдээрээ илдээ сугалцгаав. Яррист илд хөхөвтөр туяа цацруулж, жижигхэн Терн баярласан мэт улбар гэрэл цацрууллаа. Боромир баруун хаалгыг хаав.

- Хүлээж бай! – хэмээн Гэндальф Боромир руу очингуут хаалгыг бага зэрэг нээгээд: - Мориин хаант улсын агуу эзэн Балины амгалан тайвныг хэн гээч нь цочоож байна вэ? – гэж чанга хашгирав.

Хариуд нь нижигнэтэл хөхрөлдөх дуун, тушаал өгөх эрс чанга дуу сонсдоод, газрын гүнээс Р-Р-Р-Р-0-К, Р-Р-Р-Р-0-К гэсэн нүргээн гарав.

Гэндальф бөхийсхийж, хаалгаар шагайтал очир нь нүд гялбуулан гэрэлтэв. Орхуудыг яаж ч амжихын завдалгүй шидтэн хаалгыг тасхийтэл хаалаа.

- Тэнд зөвхөн орхууд л байгаа биш юм байна. Тэдэнтэй мордорын хар урхууд байна, тэд орхуудаас хавьгүй илүү аюултай. Бас хэдэн аварга том агуйн тролл байна. Бидний зам хаагдсан учир Гонхот танхим руу орцгооё.

- Зүүн тийшээ ч зам хаагдсан байх Боромир хэлэв.

- Энд одоохондоо чимээгүй байна – гэж зүүн хаалган дээр очоод ирсэн Арагорн хэлэв. – Хаалганы цаана доошоо орсон шат байгаа учир Гонхот танхим бидэнд хэрэггүй байх аа, гэвч миний бодоход араасаа хөөгдөж яваа болохоор хаашаа явж байгаагаа мэдэхгүй ухрах маш аюултай. Бид хаалгыг түгжиж чадахгүй, түгжээ нь хугарсан байна, тэгэхээр зөвхөн дотогшоо л нээгдэнэ. Эхлээд дайснуудыг зогсоох хэрэгтэй,... тэднийг түүхийн өргөөг мартахгүй болгоод өгнө гайгүй, нэг хэсэг нь энд үүрд үлдэх болно – гэж Арагорн хөмхий зуун хэлэв.

Хонгилд маш хүнд алхаанууд түжигнэв. Боромир хаалган доогуур тав зургаан хугархай илд шургуулаад, царсан самбараар гадас мэт шаав. Алхааны чимээ дуулдахаа больж, хаалгыг асар хүнд зүйлээр цохиход хаалга тэссэн боловч жаахан доргиж, дараачийн нүсэр цохилтоор бага зэрэг нээгдэн, жадан хадааснууд шаланд гүнзгий ухаадас гаргав. Гурав дахь цохилт хаалганд завсар гаргахад хар ногоон хайрстай лут том гар орж ирэв. Хаалга дахин нүсэр хүнд цохилтод доргиход хар ногоон хайрстай асар том хавтгай тавхай харагдав. Чулуун шалыг жадан хадаасаар зүсэн хаалга удаанаар нээгдэж эхэллээ.

Боромир хар ногоон гарыг илдээрээ цавчтал илд ханхийн үсэрч, Фродогийн хөл дор унав. Фродо бараг өөрөө ч мэдэлгүй “Тулаанд, Хоббитан орон!” гэж хашгираад хаалга руу ухасхийж Терн илдээ хайрст тавхай руу зоож орхив. Чих дөжрөм чанга хашгирах сонсдоод, асар том тавхай хаалганы цаагуур далд орж, чулуун шалан дээр хэдэн хар дуслууд үлдэв. Фродо илдээ арайхийн сугаллаа. Боромир хаалгыг дахин хааж, сугарч гарсан жаднуудыг дахин зоов.

- Ай даа Хоббитан! – хэмээн Арагорн дуу алдаж – Хоббитууд хайр найргүй цавчих юм байна даа, чиний илд ч гайхамшигтай юм аа, найз минь! гэв

Хаалган дээр дахиад хүнд цохилтууд буулаа. Модон хаалга байсан бол аль хэдийн бут үсрэх байлаа. Дайснууд асар том лантуу юм уу, бороохойгоор цохиж байна. Хаалга дахиад нээгдэж эхлэв. Агаарт сум исгэрэлдэж, хойт талын хананд тусаад шалан дээр унаж байна. Бүр дэргэд бүрээ дуугарч, хаалганы нарийхан завсраар орхууд ганц нэгээрээ шурган орж ирцгээлээ.

Хадгалагчид тэднийг тоолж амжсангүй, хоромхон зуурт улайрсан халуун тулалдаан болов. Орхууд ийм эсэргүүцэлтэй тулгарна гэж тооцоолоогүй учир, бие биендээ тээглэн байран дээрээ дэвслээд байв. Леголас хоёр орхыг харван унагаж, Гимли хоёрынх нь хөлийг тас цавчиж, Боромир гурвыг; Арагорн хоёрыг, Гэндальф нэгийг чадхийлгэв. Орхууд ухарч, хонгил

руу орилолдон одов.

Сэмийн мөрийг нэг орхын жад дөнгөж шүргэн бага зэрэг шалбалжээ. Сэм тэр орхыг Булнаас авсан илдээрээ нэвт сүлбэв. Сэмийн бор нүдэнд эрэлхэг дайчны гал дүрэлзэж, гэрийнхэн нь хажууд байсан бол ихэд гайхах байсан биз ээ.

- Одоо ухарцгаая, тэд нар троллуудыг дахин авчрахаас нь өмнө амжиж зайлья - гэж Гэндальф захирав.

Хадгалагчид ухарч амжаагүй байхад дайсны захирагч бололтой лужир том биетэй, Арагорноос арай намхан, өргөн, хавтгай хар нүүртэй, нүүрсний цог шиг жижигхэн улаан нүдтэй, шонтгор хамар, нарийхан духтай орк дайран орж ирэв. Тэр хар хөө хуягтай, урт түрийтэй ширэн гуталтай, мөнгөн чимэгтэй хар дуулга өмссөн байх бөгөөд зүүн гартаа бамбай, баруун гартаа урт жад барьжээ. Бусад орхууд хаалган дээр чихэлдэвч дайраад орчихож зүрхлэхгүй байгаа нь илт байв.

Захирагч орх Фродо руу ухасхийхдээ Арагорны илднээс бамбайгаараа хамгаалж, Боромирын илдэн доогуур сурмаг бултаж, жадаа шидэн хөөрхий Фродог хананд хадах дөхөв. Хоббит эр жаднаас зайлж чадсан тул жад түүний мифриль хуягнаас халтирч, хана руу нисэх зуурт Сэм дайсны жадыг тас цавчив. Фродо яахаа ч мэдэхгүй мөлхөх зуурт орх хар илдээ Фродо руу далайх хоромд хүнд Андрил илд дайсны дуулган дээр гялсхийн буув. Дайсны дуулга Дахин төрсөн Цахилгаан илднээс хамгаалсангүй, дайсны толгой тас цавчигдан уналаа. Боромир, Арагорн хоёр хаалга руу дайрахад орхууд яаран ухарч, Мориин хонгил P-P-P-P-0-K – хэмээн хүндээр санаа алдав.

- Түргэлээрэй! – Бүгдээрээ шаг руу! Тэгэхгүй бол оройтно! – гэж Гэндальф захирлаа.

Арагорн шалан дээр унасан Фродог шүүрэн сугавчлаад, Мерри, Пин хоёрыг түлхэн гаргангаа хагас нээлттэй хаалгаар оров. Бусад хадгалагчид араас нь орлоо. Леголас хамгийн сүүлд аюулыг умартан булнаас холдохгүй чаргууцалдаж буй Гимлиг чирэх шахам хаалгаар оров. Боромир хаалгыг байдаг хүчээрээ түлхэхэд чихран хаагдсан боловч түгжих юм байсангүй.

- Би шархдаагүй... Би өөрөө явчихна... – Фродо хэлэхэд Арагорн түүнийг бараг унагаачих шахав.

- Тэгэхлээр чи амьд байгаа юм уу? – гэж тэр гайхав.

- Үхсэн хүн ярьдаггүй юм. Гэвч бидэнд одоо гайхах цаг алга. Доошоо буугаад хүлээж бай, би хурдан очихгүй бол шууд явцгаа! Хаалга өмнө зүгт хоёр лиг орчим яваад хүрнэ. Нэгдүгээр давхраас доош бууж болохгүй шүү! – гэж Гэндальф тушаав.

- Би үлдэнэ - гэж Арагорн хэлэхэд:

- Буу! Энд чи илдээр юу ч хийж чадахгүй – гэж Гэндальф тушаав.

Шатан дээр цонх байгаагүй тул тэд харанхуйд буулаа. Фродо шатны гишгүүрийг тоолоход

наянтав хүргээд шатны аялал дуусав. Аянчид дээшээ харахад зөвхөн очирын гэрэл л улалзаж харагдана. Дайсан сэхээ авч чадаагүй учир шидтэн хаалганы дэргэд зогсч байгаа бололтой. Фродо амьсгаагаа арайхийн дарж зогсов. Гүнзгий амьсгалахад хэцүү байсан тул тэр Сэмийг түшиж, Сэм мөрөөр нь тэвэрчээ. Гэнэт Гэндалфын дуу сонсогдсон ч юу хэлснийг нь аянчид ялгаж сонссонгүй, бөглүүд цуурай л хүнгэнэнэ. Газрын гүнд аянга нижигнэж, хөл дорх шал доргиж байв.

Гэнэт шидтэний Очир нүд гялбуулан гэрэлтэж, харанхуйг хоромхон зуурт гийгүүлээд унтрав. Р-Р-Р-Р-0-К – хэмээн харанхуй нижигнэснээ дараа нь яг тэдний толгой дээгүүр - Р-Р-Р-Р-0-К, Р-Р-Р-Р-0-К, Р-Р-Р-Р-0-К, Р-Р-Р-Р-0-К – гэж нижигнээд чимээгүй болов. Шатаар Гэндалф бөмбөг шиг өнхрөн бууж ирлээ.

- Явцгаая! – гэж тэр хөл дээрээ босонгоо хашгираад – Аймшигтай дайсантай тулж, арайхийж дийллээ. Хурдан замдаа гарцгаая! Эхлээд харанхуйгаар явна. Надад Очир асаах хүч алга. Гимли надтай түрүүлж явна. Нэг ч алхам хоцорч болохгүй шүү. Урагшаа!

Гэндалфын үгээс хэн ч, юу ч ойлгоогүй боловч хэн ч лавлаж асуусангүй, дуулгавартай дагацгаалаа. Алсад Р-Р-Р-Р-0-К, Р-Р-Р-Р-0-К – хэмээн нүргэлж, тэр нүргээн түрүүчийнхээсээ бүдгэрсэн боловч доороос биш, араас нь хөөж байх мэт сонсогдоно. Араас хөөж байгаа өөр чимээ дуулдсангүй, хөлийн чимээ, хашгиралдаан, захиран тушаах үг аль нь ч сонсогдсонгүй. Гэндалф хаашаа ч үл эргэн чигээрээ алхах бөгөөд салаалсан хонгилууд тааралдаж байсан ч тэд яг хэрэгтэй зүг рүүгээ Зүүн хаалга руу явж байлаа. Байн байн эгц шатнууд тааралдахад шидтэн доош унахгүйн тулд очроороо таяг мэт тогшиж явлаа. Тэр очроо асааж чадахгүй байв.

Цагийн дотор тэд нэг лиг гаруй зам туулсан ба шатаар хэд хэдэн удаа доош бууж, чив чимээгүй, таг харанхуй дундуур урагшилж байв. Гэвч тэд алхам тутамдаа араас хөөгөөгүй гэсэн итгэл төрж байлаа. Хамгийн урт, долоо дахь шатаар буугаад (Фродо гишгүүрийг нь тоолоход зуу хүрчээ) Гэндалф ядрангүй зогсч:

- Миний бодлоор бид нэгдүгээр давхар руу буучихлаа. Энэ хонгилоор цаашаа явбал Өмнөд жигүүр хүрнэ. Одоо зүүн тийшээ эргэнэ. Хаалга одоо ойрхон байгаа гэж найдаж байна. Би маш их ядарч байна. Амрах хэрэгтэй, тэгэхгүй бол би Хаалга хүрч чадахгүй нь - гэв.

Гимли шидтэнийг мөрөөрөө түшин буулаа.

- Тэр нүргэлээд байсан юмыг чи зогсоосон уу? Ямар гүнээс гарч ирсэн юм бол? – гэж Гимли асуув.

- Мэдэхгүй ээ, би тийм хүчирхэг дайсантай анх удаагаа тулгарсан, тэгээд тайлагдашгүй тарниар хаалгыг хаахаас өөр арга байсангүй. Би олон тайлагдашгүй тарни мэднэ, тэдгээрийг тайлахад их хугацаа шаардагдана, ингэлээ гээд хаалга бөх болохгүй, хаалгыг нээж болохгүй, хэмхэлж болно.

Би орх, троллуудтай тулгарна гэж бодсон юм. Хаалганы цаана тэдний дуу гарч байсан, гэвч юун тухай ярилцсаныг нь мэдэж чадаагүй, тэдний тэр хачин хэлийг ойлгоход маш хэцүү. Гэвч нэг үг барьж авсан, тэд байнга л “гхаш” гэсэн үг давтаад байсан, орчуулах юм бол “гал” гэж

байгаа юм. Дараа нь тэдэн дээр холбоотон нь ирсэн, тэд тэрнээсээ ухаангүй айдаг юм билээ. Тэр нь хэн юм, юу юм гэдгийг би ойлгоогүй, гол нь тэрэнтэй халз тулалдахад дийлэх эсэхээ мэдэхгүй байсан. Тэр тайлагдашгүй тарнийг тайлж байсан, би хамаг чадлаараа эсэргүүцсэн ч хаалга хариугүй нээгдэх гээд байсан, тэгэхээр нь би хамаг хүчээ шавхаж байгаад хариулах хараал хийсэн. Гэвч хаалга хоёр их хүчний тулалдаанаас болоод зад үсэрсэн. Чулуун хаалга шүү дээ!

Би юу ч харж чадаагүй, тасалгаанд улайдсан, арзгар харанхуй хар үүл бүрхсэн байлаа. Би түүнтэй учрахад бэлэн биш байсан, аз болоход тасалгааны хананууд нижигнэн нурж, намайг доош нь авч шидсэн.

Морийн хаан Балины булшин дээр жинхэнэ хааны бунхан баригдсан байна лээ. Миний дайсанг нураасан байх гэж найдаж байна... гэхдээ тийм ч итгэлтэй биш байна. Ямар ч л гэсэн бид цаг хожлоо, тэр нуранги биднийг мөрдөн хөөгчдөөс зааглалаа. Энэ халз тулаан намайг мөн ч цуцаалаа даа! Гэхдээ юу ч биш, миний хүч тамир сэргэж байна... Тийм ээ, ингэхэд Фродо яасан бэ? Тэрний дуу сонсдоход би чихэндээ итгээгүй шүү. Арагорны тэвэрт гайхалтай эр зоригтой боловч амьгүй хоббит байх шиг харагдсан шүү.

- Би амьд... миний бодлоор бол гэмтээ ч үгүй байна, гэхдээ цээжин дээр том хөх толбо гарсан байх, энэ яахав одоохон эдгэчихнэ – гэж Фродо хэлэв.

- Хоббитууд ёстой хайр найргүй цавчдаг юм байна, ер нь бие нь мифрилээр хийгдсэн байх аа гэж Арагорн учиртайхан жуумалзаж – Одоо би Уулын сууринд бүдүүн Наркиссын уушийн газарт эд нарт өөрийгөө хүчээр шахуу тулгаж өгөхдөө ямар ноцтой аз сорьсноо ойлгож байна. Тэр орх зэрлэг бухыг ч нэвт сүлбэж чадах дайчин байсан шүү!

- Аз болоход намайг нэвт сүлбэчихсэнгүй – гээд Фродо цээжээ илэн – гэхдээ би алх, дөш хоёрын хооронд орчих шиг санагдсан. Тэр цааш нь ярьсангүй, үнэхээр амьсгалахад цээж нь өвдөж байв.

- Чи надад байн байн Бильбог санагдуулаад байх юм, тэр ч бас хамт яваа нөхдөө гайхуулах дуртай байсан юм – гэж Гэндалф хэлээд Фродо руу харав.

Арагорн, Гэндалф хоёрын хэлсэн үгийг эргэцүүлээд Фродо энэ хоёр яг бодсон юмаа бүрэн хэлсэн болов уу гэж бодов.

Аянчид хонгилоор өмнө зүг рүү явж байтал Гимли гэнэт:

- Та нар гэрэл харж байна уу? Тээр урд талд? Миний бодлоор энэ бол түймрийн туяа байна - гэв.

- Гхаш гэж шидтэн өөрийн эрхгүй бувтнаснаа – Тэд юун тухай ярьж байсан нь сонин байна? Гэвч бидэнд өөр сонголт байхгүй, явах л хэрэгтэй... – гээд хурдлан алхав.

Гимли үнэн хэлжээ. Гучаад алхам яваад хонгил огцом доошилж, аянчид дотор талаасаа галын гэрлээр гийсэн намхан нуман хаалга үзэв. Хонгилд гэрэлтэй, халуун боллоо.

Гэндальф зогс гэсэн дохио өгөөд нуман хаалгаар орсноо нам зогсов, тэнд улалзсан гал дүрэлзэж байлаа.

- Бидэнд тансаг угталт бэлтгэсэн байна – гэж тэр эргэж ирээд мэдээлж: - Одоо бид хаана ирээд байгааг би мэдлээ. Нуман хаалганы цаана Садар өргөө байгаа, Зүүн, Баруун хаалгануудыг холбосон Гол их зам тэр дундуур гарна. Бид нуман хаалгыг өнгөрөөд зүүн тийш эргэнэ, Садар өргөө биднийг Гүүрэнд хүргэнэ, бид Морийн жалгыг өнгөрөөд шатаар дээш гарч, Хар голд хүрнэ! Хаалга хүртэл одоо хагас лигээс илүүгүй зай байгаа. Бидэнд яаж аз гийж байгааг одоо харцгаа.

Аянчид Садар өргөөг шагайж харав. Тэр бол Хориннэгдүгээр өргөөнөөс уудам бөгөөд өндөр таазтай ажээ. Уртааш сунасан танхимын голд аварга хүдэр чулуужсан модтой төстэй хоёр эгнээ чулуун багана байна. Моднуудын мөчир дээш сарайж бүрэнхийд харагдахтай үгүйтэй таазыг тулжээ. Нуман хаалганаас холгүйхэн өргөн ангал байх бөгөөд дотор нь гал дүрэлзэж, мод - баганы хар гол дээр улаан туяа татна. Заримдаа галын дөл баганыг могой мэт ороон долоож байлаа. Ангалын дээгүүр утаан үүл хөшиглөжээ.

- Хэрэв бид Гол замаар явсан бол биднийг энэ ангалын дэргэд сүйд хийх байжээ – гэж Гэндальф толгой сэгсрэн хэлээд – Бидний аз болж, энэ ангал араас мөрдөгчдийг саатуулна гэж найдъя. Гэхдээ сатаарч цаг алдаж болохгүй...

Гэндальф ингэж хэлж дуусав уу, үгүй юу нүсэр нүргээн, занасан хашгиралдаан, эвэр бүрээний дуу сонсдов. Нүргээнээс чулуун баганууд доргиж, галын дөл намсан бүүдгэрч байв.

- Миний хойноос! – хэмээн Гэндальф тушааж – Хэрэв өнөөдөр нарлаг өдөр бол орхууд агуйгаас гарч зүрхлэхгүй. Сүүлчийн хүчээ дайчилцгаая, тэгээд л бид аврагдана!

Гэндальф нуман хаалгаар яаран гарч, зүүн зүг рүү гүйв. Танхим тэдний бодсоноос илүү урт байсан бөгөөд шал нь тэгшхэн учир тэд ядраагүй байсан сан бол гүйхэд ямар ч саад байсангүй. Ангалын цаанаас чих дөжиртөл орилолдов. Орхууд тэдний гүйж байгааг харчихжээ. Фродогийн толгой дээгүүр сум исгэрэн өнгөрөв. Боромир эргэж хараад тачигнатал инээв.

- Мөн галзуурцгааж байна аа! – Бусдад битгий урхи тавьж бай! – гэж тэр хашгирлаа.

- Баярлах болоогүй шүү! – гэж шидтэн түүний үгийг таслаад – Урд талд аюултай нарийхан гүүр байгаа – гэв.

Төдөлгүй тэдний өмнө харанхуй ангал, хашлагагүй, тавь жаран алхам урт нарийхан гүүр гарч ирлээ. Гномууд тэр гүүрийг барихдаа дайснууд хаалгыг эвдлээд орж ирвэл Морийг хамгаалах гэж ийм нарийхан барьжээ. Гүүрээр цэвэрч явахаас өөр арга байхгүй. Гэндальф гүүрэн дэр гүйж хүрээд зогсоход аянчид түүнийг амьсгаадан тойров.

- Гимли – түрүүл, араас нь хоббитууд, Леголас, хүмүүс – гэж шидтэн тушаалаа.

Фродогийн нуруунд сум тусч, хуягнаас халтирч газарт жингэнэн унав. Шидтэний малгайд

туссан нэг сум хар өд мэт гозойж харагдав. Фродо эргэж харахад ангалын цаана галын гэрэлд хэдэн зуун орхууд чихэлдэж байв. Тэд урт жад, хар илднүүдээрээ даллан - P-P-P-P-0-K, P-PP-P-O-K, P-P-P-P-0-K, P-P-P-P-0-K хэмээн орилолдоно..

Леголас саадагнаасаа нэг сум гаргаснаа эргэж хараад айсан дуугаар хашгирч сумаа алдав. Ангалд хоёр аварга том тролл урт чулуун хавтан барьсаар дөхөж иржээ. Тэд гүүр тавих бололтой. Гэвч эльф дайчин троллуудаас айгаагүй ажээ. Орхууд гэнэт айн ухарч, арзайсан хар үүлээр бүрхэгдсэн аварга том сүүдэр гарч ирэв. Түүнд амьд бүхнийг айдаст автуулсан асар их хүч байгаа нь илэрхий байлаа.

Ангалын дэргэд хар үүл хоромхон зуур зогсоход галын дөл утаан хөшгөнд хаагдах адил үзэгдэхгүй болов. Дараа нь орхуудын аймшигт холбоотон улайдсан ангалыг хөнгөхөн харайн давахад унтарч байсан гал баяр хүргэх мэт улалзан бадарч, арзгар үүлийг гэрэлтүүлэхэд үүлний харанхуй хар өнгө өтгөрч, баруун гартаа гал, зүүн гартаа урт галан шилбүүр барьсан аварга том хүний дүрс тодров.

- Амиа аварцгаагаарай! – Энэ чинь Барлог байна! Тэрнийг устгах боломжгүй! Амиа аварцгаа – гэж Леголас бачимдан хашгирав. Гном баатрын нүд айдсаар дүүрэн байлаа.

- Агуу Лихо Дарин гэдэг чинь энэ – гэж тэр шивнээд сүхээ унагаж, хоёр гараараа нүүрээ дарлаа.

- Барлог, - одоо ойлгомжтой боллоо - гэж Гэндальф сөөнгөтөн хэлээд – Тэр очрыг унтраажээ. Би үхлээ ядарсан байна.

...Барлог хадгалагчид руу маш хурдан ойртож ирлээ. Троллууд ангалыг хавтангаар хааж, орхууд Барлогийн араас хөдлөв. Боромир эвэр бүрээгээ хүнгэнэтэл үлээхэд Гондорын байлдааны уриа цуурайтай нийлэн довтолж буй үй олон орхууд зогсоолоо. Барлог хүртэл хоромхон зуур зогсов. Цуурай намдахад дайснууд урагшлав.

- Гүйгээрэй! Хурдал! - гэж Гэндальф тушааж: - Шатаар өгсч, Толин нуур руу ухар. Энэ дайсанг та нар дийлэхгүй. Би ч зогсоож чадахгүй, орхууд троллуудтай хүч хавсарна. Би тэрнийг гүүрэн дээр угтана – гэлээ. Аянчид гүүрээр цувран гарч, шатны дэргэд зогсоод Гэндальфыг ганцааранг нь орхиж чадахгүй тээнэгэлзэв. Боромир, Арагорн хоёр жалганы дэргэд нам зогсов.

Барлогын хар биеийг хучсан галт хар үүл нарийхан гүүр рүү яаралгүй ойртож байна. Гүүрний дунд Гэндальф очроо тулаад ядарсандаа бөхийн зогсоно. Барлог нэг мөчийн төдий хөдөлгөөнгүй зогсч, арзгар үүл нягтран хоёр тийшээ далавч болон салж, олон сүүлтэй галан шилбүүр нь хүрэн улаан очис цацруулан тас нясхийж, улайдсан галан илд тодров. Гэндальф байрнаасаа огт хөдөлсөнгүй.

- Явцгаа - гэж аяархан хэлэв. Орхууд чив чимээгүй болж, Садар өргөөнд их аяндын өмнөх шиг зэвүүн нам гүм боллоо.

- Би мөнхийн наран галд зүтгэдэг, Анорын гэгээн галын эзэн. Чамд Хүрэн харанхуй тус

болохгүй. Гүний гал газар дээр хүчгүй болдог юм. Чи энэ гүүрээр гарна гэж байхгүй. Яв! – гэж Гэндальф аяархан хэлэв.

Барлог Гэндальфт юу ч хэлсэнгүй. Далавчных нь гал унтарсан боловч илд нь хар хүрэн өнгөөр туяарч, шилбүүрнийх нь сүүл бүдэгхэн гэрэлтэж харагдана. Тэр урагш алхахад гэнэт хар далавч нь аварга том болж, шидтэний дээгүүр бүрхлээ. Гэвч Гэндальфын мөнгөлөг саарал өнгөтэй харагдах биеийн дээгүүр Барлог хоёр далавчаа нийлүүлэх хүч хүрэхгүй байгаа нь илт байв.

Тэр суларсан далавчаа буулгаад хар хүрэн илдээ өргөлөө.

Хөхөвтөр туяат Яррист илд хүйтэн өнгөөр гялсхийв.

Аянчдын нүдийг хурц цэнхэр туяаны цацраг гялбуулж, хан хийх чимээ дуулдаад, хар хүрэн илд олон мянган хэлтэрхий болон зад үсрэв. Барлог цочин овгосхийж, гэдрэг ухрав. Шидтэн ганхасхийсэн боловч байрнаасаа хөдөлсөнгүй.

- Чи энэ гүүрээр гарахгүй – гэж тэр хэллээ.

Барлог үг дуугүй урагшлав. Чанга исгэрээд шилбүүрээ чих дөжрөм чанга шилбүүрдэв.

- Тэр ганцаараа дийлэхгүй! – гэж Арагорн хэлээд нарийхан гүүрээр шидтэн рүү гүйв. - Элендил! – гэж тэр чанга хэлээд – Би чамтай хамт, Гэндальф, бид хоёр тэрнийг ялна!

- Гондор! - гэж Боромир сүрлэг хашгираад Арагорны хойноос хурдлав.

Гэндальф Шидэт очроо өргөтөл, Очир жижигхэн нар мэт хурц гэрэл цацруулж, шидтэн очроо Барлогийн өмнөх замыг хаах мэт огцом доош буулгав. Мөнгөлөг дөл бадран асч Шидэт очир дундуураа хуваагдан, Барлогийн өмнөх гүүр харанхуй ангал руу алга болов.

Барлог сөөнгөтөн хашгирч доош унахдаа шилбүүрээ толгой дээгүүрээ эргүүлэн, шидтэнийг хоёр удаа ороолгов. Барлогийн нүсэр хүнд жинд татагдсан Гэндальф доош унахдаа гүүрнээс барьж авсан боловч, тогтож амжсангүй: “Түйцгээ-гээ-рэй!” – гэж хашгираад Морийн хар ангал руу алга болов. Амнаасаа цухуйж буй хэл адил нурсан гүүрний хагас харанхуйд чичигнэж харагдлаа.

Чимээгүй харанхуй нөмөрлөө. Аянчид айсандаа дуугарч чадахгүй зогсов. Арагорн, Боромир хоёр түрүүлж сэхээ орон шат руу ухарч гармагц гүүрний үлдэгдэл харанхуй ангал руу хийсч одов. Арагорн нам гүмийг эвдэж:

- Явах хэрэгтэй – гэж нөхдөдөө хэлээд – Энэ бол түүний сүүлчийн хүсэлт. Одооноос эхлээд би бүлгийг удирдана -гэв.

Харанхуй эгц шатны гишгүүрт бүдчин байж аянчид Арагорны араас дээш өгслөө. Боромир цувааны сүүлд явлаа.

Шат тэднийг бөглүү цуурайлсан хонгил руу оруулж, Арагорн сааталгүй урагшлав. Фродогийн

хажууд Сэм уйлан алхаж, Фродо ч өөрөө чимээгүй уйлж явлаа. P-P-P-P-0-K, P-P-P-P-0-K, P-P-0-K... P-O-K... гэсэн дуулдах төдий нүргээн шалыг үл мэдэг чичрүүлнэ.

Тэдний өмнө гэрэлтэй танхим харагдав. Хадгалагчид өөрсдөө ч мэдэлгүй алхаагаа түргэсгэлээ. Танхимыг дөрвөн урт нарийхан цонх гэрэлтүүлжээ. Хонгилын эсрэг талд чулуун хаалга харагдав. Хаалгыг нээхэд их өндөр, нүд гялбам гэрэлтэй Нуман хаалга байлаа.

Үнэн хэрэгтээ Хаалга байсангүй, аль эрт үгүй болсон учир тэдэнд гарц л харагджээ. Гарцын дэргэд харуулын таван орх сүүдэрт тайван зүүрмэглэж байна. Тэд хадгалагчдыг энд хүрээд ирнэ гэж зүүдлээ ч үгүй бололтой. Эхлээд харуулын ахлагч ухасхийн боссон ч Арагорны илдэнд цавчуулан унав. Үлдсэн орхууд үхтлээ айн зугтлаа. Хадгалагчид гарцанд хурдлан хүрч, эртний чулуун шатаар буулаа.

Аймшигт аялал ийнхүү өндөрлөв.

Арагорн амсхийлгүй урагшилсаар, орхуудыг аянчдын мөрөөр орохоос өмнө Хаалганаас холдох хэрэгтэй гэж тэр шийджээ. Аянчдын өмнө Хар голын хөндий цэлийж байв. Манант уулс нарыг халхалж байвч хөндий найрсгаар алтран, сэмжин цагаан үүлтэй тэнгэр цэнхэртэнэ. Дөнгөж л үд болж байна.

Тэд зогсоод эргэж харлаа. Манант уулсын бэлд асар том нуман хаалга харлаж харагдана. Хаа нэгтээ газрын гүнд дөнгөж сонсогдох төдий - P-P-P-P-0-K, P-PP-P-0-K... P-P-O-K... P-O-K... гэсэн бүдэг чимээ гарч байв.

Тэгээд аянчид уй гашуугаа барьж дийлэлгүй нулимсаа дураар нь асгарууллаа. Зарим нь чимээгүйхэн уйлан зогсоход зарим нь эхэр татан газраар өнхөрч байв. Хатуу ширүүн Боромир хүртэл уйлж байлаа. Газрын гүнд дахин нэг удаа - РОК, - гэж сонсдох төдий санаа алдах мэт чимээ гараад хөндийд нам гүм болов.

Бүлэг 18

Квэтлоризэн

Ходлох цаг боллоо - гэж Арагорн хэлэв. Тэрбээр эргэж харснаа Андрил илдээ авч: - Баяртай, Гэндалф! Би чамд “үхлийн аюул тулгарч байна” – гэж хэлсэн шүү. Харамсалтай нь миний зөв байлаа – бидний аялал найдваргүй болж байна! – гээд Арагорн: - Бид Мордор руу ямар ч найдваргүй явж байна. Магадгүй, бид өшөөгөө авч чадах ч юм билүү. Гэхдээ бидэнд харамсах цаг алга байна, андууд минь. Бид олон хүнд бэрхшээлтэй зам туулах болно.

Аянчид нулимсаа арчаад эргэн тойрноо харлаа. Умар зүгт, Манант уулын нарийхан хавцлаар цагаан саарал өнгөт хөөсөрсөн ус хясаанаас хясаанд үсчин бууж, түүнээс цаахна зүүн хойт зүгт гурван аварга оргил - Фануиндхол, Карадрас и Селебдор сүндэрлэнэ.

- Харж байна уу? Энэ бол Хар голын хаалга. Тэндээс л бид Хар гол руу орох учиртай. Хүрэн хаалга бидэнд аз авчрах болтугай – гэж Арагорн налуу хавцал руу зааж өгүүлэв.

- Харин Баразинбар бидэнд туслахын оронд дооглосон. Хараач тэрнийг, хараал идсэн хар золиг чинь шоолж байна! – гэж Гимли алсын уул руу гар зангидан занав.

Манант нурууны салбар уулс мөнгөлөг хөөст хүрхрээнүүд бүхий хавцлууд үүсгэн дорно зүг рүү бүтэн хагас лиг сунажээ. Тэндээс мөнгөлөг голын голдрил өргөсч, мандалд нь Манант уулын сүүдэр туссан том зуувин нуурт цутгатлаа амгалан урсана. Гэвч тэр нуурын мандал уулын сүүдэр нөмрөөгүй талдаа ч хүртэл бараантаж харагдав. Иржгэр давалгаангүй, толь мэт хөдөлгөөнгүй ус гэрэлтэй тасалгааны цонхоор харагдаж байгаа үдийн тэнгэртэй адил байв. Нуурын мандлыг тод ногоон нуга хүрээлжээ.

- Та нар санаж байна уу, би Остраннад байхдаа түүнээс “Дархан нуураа харах завшаан надад тохиолдох юм гэж үү дээ?” – гэж асууж байсан даа. Одоо би Толин нуурыг харж байна, гэвч өөрийгөө өнчин, аз жаргалгүй амьтан шигээр төсөөлж байна... – гэж Гимли гунигтай өгүүлэв.

Хадгалагчид зургаан өнцөгт хагархай хавтангуудаар тавьсан эртний замаар алхав. Хавтангуудын хагархайгаар өвс ургажээ. Зам довцог толгодтой тал руу орж, Толин нуурын дэргэдээс эргээд зүүн өмнө зүг рүү чиглэж, дараа нь Мөнгөлөг голын эргээр зурайжээ. Замын хажуугаар баруун зүүн талд эвдэрсэн чулуун хөшөөнүүд тааралдана. Нуурын эрэгт орой нь нурсан аварга том багана байна.

- Энэ чинь Дарины багана байна шүү дээ! – гэж Гимли дуу алдсанаа - Арагорн, би нуур руу буучихаад ирж болох уу?

- Хурдан ирээрэй - гэж Арагорн тэнгэр өөд харангаа хэлээд – Нар гурван цагийн дараа жаргана. Өдөр орхууд агуйгаасаа гардаггүй, шөнө болохоор бидний араас хөөнө, тэгэхлээр аль болохоор холдох хэрэгтэй байна. Шөнө саргүй харанхуй байх тул орхууд ер бусын аюултай.

- Явцгаая, чи Келед-Зарамыг үзэх ёстой - гэж гном дайчин Фродог дуудаад доош гүйж одов.

Фродо уй гуниг, ядаргаагаа дийлж, Толин нуур руу буухад Сэм эзнийхээ араас дагалаа.

Гимли баганын дэргэд саатаж, хоёр хоббитыг хүрч очиход:

- Харж байна уу, энд морио хэлээр: “Эндээс Дарин анх удаагаа Келед-Зарамыг харсан” гэж бичжээ. Баганан дээр хагас баларсан рун бичиг байх боловч унших боломжгүй ажээ. Элс, салхи хоёр бичээсийг арилгажээ. Одоо бид ч гэсэн нуурыг харъя - гэж Гимли хэлэв.

Тэд харлан харагдах ус руу тонгойлоо. Эхлээд юу ч харсангүй. Дараа нь нуурын толин цэнхэр мандалд нартай өдөр байтал одод мөнгөрөн гялалзаж, өндөр уулсын цаст оргил үзэгдэв. Яагаад ч юм нуурын усанд өөрсдийнх нь дүр тусч харагдаагүй тул тэд гайхаж, эргээс холдлоо.

- Сайн байна уу, бас баяртай, Дархан Нуур минь! – гэж Гимли гүнээ мэхийн хэлэв. Тэгээд хоббитууд руу харж: - Энд Дарины титэм байгаа юм. Титэм эзнээ сэрэхийг хүлээж байгаа юм...

- Чи тэнд юу харав? – гэж Пин тэднийг гүйцэж очиход Сэмээс асуув. Гэвч бодолд дарагдсан Сэм юу ч хэлсэнгүй.

Үржил шимт хөрстэй хар хадан уултай уудам хөндийг хойт талаас нь Мөнгөлөг гол, өмнө талаас нь Цагаан дэлт гол хашжээ. Тийм учраас голын ёроол хар өнгөтэй, эртнээс Хар голын хөндий гэж нэрлэж ирсэн ажээ. Гэхдээ нарлаг өдөр хоёр гол мөнгөлөг өнгөөр гялалзан харагддаг, үдэш оройд юм уу бүрхэг өдөр л харлаж харагддаг байна. Магадгүй эндхийн анхны оршин суугчид бүрхэг өдөр ирсэн байж ч мэдэх юм.

Аянчид Мөнгөлөг голын эргээр алхав.

- Толин нуураас Мөнгөлөг, Цагаан дэлт хоёрын уулзвар хүртэл арваад лиг алхана, тэнд ойд хоноглож болно. Энэ замыг Гэндальф Их мөрөн рүү орох дөт зам гэж сонгосон юм. Мөнгөлөг, Цагаан дэлт хоёр гол нийлээд их уст Алтан гол болно, тэр гол Их Андуин мөрөнд цутгадаг юм – хэмээн Арагорн ярьж явлаа.

- Хоёр гол Кветлориэний дэргэд нийлдэг юм – гэж түүний яриаг Леголас баяртайгаар залгаж аваад – гайхамшигт Алтан ойд байдаг эльфүүдийн хамгийн сайхан суурин. Кветлориэний мөнгөн модод (мөнгөлөг саарал холтостой байдаг юм) намар орой ч өтгөн навчсаа гээдэггүй, алтлаг шаргал өнгөтэй болоод хавар хүртэл мөчир дээрээ байдаг, хавар хагдрахаараа ойн газрыг алтан шаргал болгодог, мөчир дээр нь шинэ навчистай хамтаар алтан шаргал цэцэгс дэлгэрч, агаарыг балын амттай болгодог юм. Эртний домогт л ингэж өгүүлдэг юм л даа, би өөрөө Лориэнд нэг ч удаа очиж байгаагүй. Хавар тэнд очих юмсан!

- Тэнд өвөл очиход ч сайхан, гэхдээ Лориэн хол байна. Одоо бид Моригоос холдох хэрэгтэй байна, тиймээс алхаагаа нэмцгээ, андууд минь - гэж Арагорн хэлэв. Арагорн түрүүлэн том том алхаж, Сэм Фродо хоёр алхааг нь гүйцэхгүй хоцорч эхлэв. Тэд өдөржингөө юу ч идсэнгүй. Сэм илдний үзүүр шүргэсэн шалбархайнаас үүдэн толгой нь эргэж, бага зэрэг

халуурч байв. Халуун Мориугоос гарснаас хойш тэнгэрт нар гийж байсан ч салхинд чичирч явлаа. Фродо сөөнгөтөн амьсгаадаж, алхахад улам бэрх болж байв.

Хагас цагийн дараа Леголас эргэж хараад хоббитууд хол хоцорсныг мэдэж, Арагорнд хэлэв. Тэр эргэж хараад хоббитууд руу гүйж очив. Хойноос нь Боромир ирлээ. Бусад нь шууд зогсов.

- Уучлаарай андууд минь, өнөөдөр олон янзын үйл явдал болсон учраас би та нарыг Мориугоос аль болохоор их холдуулахын тулд яарч байгаад та хоёрын шархыг ч мартчихаж - гэж Арагорн хэлээд – Та хоёр ч гэсэндээ, бидэнд сануулахад яадаг байна! Бид түр зогсоод шархыг чинь харах байсан юм!.. одоо жаахан тэвчиж үз. Амрахад аятайхан газар урд байгаа, тэнд очоод би чадах бүхнээ хийнэ. Алив, Боромир, хоёулаа энэ хоёрыг тэврээд явъя!

Удалгүй аянчид Мөнгөлөг голд намуухан шоржигнон нийлж байгаа горхи харав. Тэгсгээд Мөнгөлөг гол нэгэн хар босго даваад голдрил нь өргөсөн тэлж, өргөслөг бутнууд дундуур урсчээ. Арагорн өргөст бутнууд дундуур зүтгэж гараад дал модоор хүрээлэгдсэн жижигхэн талбайд хүрэв. Тэнд түр буудаллав. Нар баруунаа ташиж эхэлсэн, тэд хэдхэн лиг явсан, орхууд араас нь амархан гүйцээд ирж болохоор байв...

Хадгалагчид хуурай мөчир түүж, гал асаах зуурт Арагорн хоёр хоббитын шархыг үзлээ. Сэмийн шарх өнгөцхөн боловч цус шүүрч байсан тул Арагорн санаа зовж Сэмийн дээрээс тонгойж үзэв. Гэвч айх юм байхгүй нь илт байлаа.

- Чамд аз таарч, олон дайчин эхнийхээ орхыг устгасныхаа төлөө үүнээс хамаагүй их юм амсдаг юм. Чиний шарх хоргүй илднийх байна. Олон орх маш хүчтэй хороор илднийхээ ирийг хордуулсан байдаг. Ийм шархыг бид амархан эмчилнэ – гээд Арагорн үүргэвчнээсээ хатаасан навч гаргаж ирэв: - Энэ бол анагуурын навч. Би Эргүүлэг уулнаас холгүй газраас түүсэн юм. Хатаасан навч шинэ навчнаас хүч султай боловч чиний шалбархайг эдгээнэ. Буцалсан усанд хийгээд хөргөж, шархаа угаагаад болгоомжтой үр. Одоо чиний ээлж, Фродо.

- Миний бие сайжирч байна – гээд мань хоббит Арагорн цувьг нь тайлах гэхэд тайлуулсангүй – Би зүгээр л ядарч, өлссөн, хоол идээд жаахан амарчихад л болно, бүрэн эдгэнэ.

- Алх, дөш хоёрын хооронд хавчуулагдах ч тоглоом биш дээ – гээд жуумалзсанаа: - Хавирга чинь хугарсан бол яах вэ? Үгүй ээ, эсэргүүцээд хэрэггүй, би үзье! – гээд Фродогийн цув, цамцыг тайлснаа... ихэд гайхан хөмсөг зангидаж, тэгснээ инээв. Хөө хуяг Мөнгөлөг гол наранд гялалзах шиг туяа цацруулан байв. Арагорн түүнийг тайлаад зөөлөн сэгсрэхэд үнэт эрдэнийн чимэг нь баяртайяа гялалзаж, хуягны нарийн цагаригнууд зуны шиврээ борооны чимээг санагдуулан шижигнэлээ.

- Андууд минь, манай Фродогийн үнэт арьсыг хараач хөөе, - гэж Арагорн дуу алдаж: - Хэрэв хоббитуудад ийм үнэтэй арьс байдгийг Дундад газрын ангуучид мэдэх юм бол ч Хоббитан руу сүрэг сүргээрээ цувна даа...

- Дундад газрын хамгийн дээд зэргийн ангуучдын сум ч хоббитуудад өчүүхэн төдий ч хор хүргэхгүй – гэж Гимли хөө хуягийг сонирхох зуураа хэлээд – Энэ чинь мифрилээр хийсэн хөө хуяг байна шүү дээ! Мифрилээр шүү!!! Би ийм агуу бүтээлийг нэг ч удаа хараагүй – ийм юм

бүтээх боломж бий гэдгийг ч мэдэхгүй байсан. Гэндалф энэ хөө хуягийг ярьсан юм биш биз? Тийм бол тэр энэ хөө хуягийг арай л дутуу үнэлж дээ.

- Тийм байх аа, - Энэ яагаад Бильбогийн өрөөнд ингэж их удаан суув гэж би бодож байсан юм. Тэр чамайг аян замд үдэж, зэр зэвсгийг чинь бэлтгэж өгчээ. Ямар гайхамшигтай өвгөн бэ! Чиний бэлэг Фродог үхлээс аварсан гэж боломж олбол түүнд дуулгах юмсан – гэж Мерри ярианд оролцов.

Хөө хуяганд туссан жад мифрил цагаригнууд дотуурх нимгэн зөөлөн илгэн цамцыг дарж, Фродогийн цээжин дээр хөх толбо үүсгэсэн боловч хөө хуяг цоорсонгүй, хальтирсан жад цувьг нь нэвтлэн мань хоббитыг хажуу тийш нь огцом шидэж, хананд эрвээхэй шиг наасан тул мөрний тус газарт том хөх толбо гарсан байв. Бусад нь хоолоо хийж байх зуур Арагорн анагуурын ханд бэлтгэж, хоббитын бүх хөх толбыг угааж, шавшив. Салхинаас хамгаалагдсан хонхор газарт анагуурын хурц үнэр тархаж, төдөлгүй ядаргаа тайлагдаж байгааг аянчид баяртайгаар мэдрэв. Сэмийн шалбархайнаас цус шүүрэх нь зогсч, Фродо амьсгалахад хөнгөн болсон ч жаднаас үүссэн хөх толбо олон хоног өвдөж, хөө хуягаа өмсөхөд нь хөнгөн болгохын тулд Арагорн зөөлөн боолт хийж өгөв.

- Чи хуягтайгаа байсан цагт хаа сайгүй тайван байгаагаа мэдрэх болно. Аялал дуустал биенээсээ салалгүй өмс, тэгээд ч гайхалтай хөнгөхөн юм байна. Дайсны агуу хүч үйлчлэхгүй газарт очихоороо найз нарынхаа дунд хуягаа тайлж болно... гэвч харамсалтай нь бидний явах замд тийм дархан газар цөөхөн таарна.

Хадгалагчид амарч хүчээ сэлбэж аваад галаа унтрааж, үнсийг нь дал модны дээд талын мөчрүүд рүү цацаж, ул мөрөө баллаад Арагорны араас цувралдан замаа хөөв. Цаг орчим явсны дараа Манант нуруу жаргаж буй нарыг аянчдаас хааж, ууланд хар сүүдэр хүүшиллээ. Голын зүгээс цайвар манан дэгдэв. Дорно зүгт үдшийн саарал бүрэнхий уудам талыг аажмаар бараантуулж, алсад байгаа ойг ойрхон юм шиг харагдуулж байв. Сэм, Фродо хоёр сэргэсэн болохоор аянчид хангалттай хурдан урагшилж, дахин гурван цаг яваад ганцхан удаа богино амарлаа.

Хөндий шөнийн харанхуйд хучигдав. Тэнгэрт одод хурцаар гялалзан, сар хараахан гарах болоогүй. Гимли харанхуйд чих тавин цувааны сүүлд явж байв. Эргэн тойрон нам гүм, Гимли шөнийн нам гүмийг эвдэж:

- Араас хөөсөн ямар ч чимээ алга байна, эсвэл миний чих царс модны хожуул шиг дүлийрсэн байх. Магадгүй орхууд биднийг Мориугоос хөөж явуулахын тулд л довтолсон ч байж болох юм. Харин манай бүгдийг захирагч бөгжний талаар юу ч мэдэхгүй, мэдэхийг ч хүсэхгүй байж болох биш үү? Гэхдээ тэд өшөөгөө авах гэж дайснаа удтал мөрдөн хөөдөг нь үнэн л дээ...

Фродо Терн илдээ сугалж дээш өргөхөд ир нь гэрэлтсэнгүй. Гэлээ ч гэсэн тэр ямар нэг алхааны чимээ сонсч байв! Харанхуй болсноос хойш түүнд нүцгэн хөлийн чимээ сонсдож эхэлсэн ба заримдаа салхины чимээнд дарагдаж байлаа. Эсвэл зүгээр л тэгж санагдаад байгаа юм болов уу? Үгүй дээ, яг одоо ч гэсэн сонсч байна... тэр огцом эргэж харсан чинь зам дээгүүр хоёр гэрлэн цэг хөвж байх шиг. Нүдээ цавчилж байгаад сайтар харахад юу ч үзэгдсэнгүй.

- Ядраад байна уу? – гэж Гимли санаа зовнингуй асуулаа.

- Үгүй ээ, харин бидний араас хэн нэгэн гэтээд байх шиг санагдаад байна. Би байнга нүцгэн хөлийн алхаа сонсоод байна. Сая би хоёр нүдний гал ёлтолзохыг харлаа... Өөр юу ч харагдахгүй байна – гээд Фродо дуугүй болов.

Гимли эргэж харан чимээ чагнаснаа:

- Чи буруу ойлгож байна – Энэ бол салхинд өвч сэрчигнэх чимээ, харин галын хувьд гэвэл... хичнээн олон сүүмэлзсэн гал байна! - гээд Гимли шөнийн тэнгэр өөд зааж - Явцгаая! Бид хоёр нөхдөөсөө хоцрох нь байна.

Салхины исгэрээ улам өтгөрч, урд талд шөнийн харанхуй нягт болоод ирэхэд аянчид ой руу ойртож байгаагаа мэдэв.

- Энэ бол Кветлориэн! - хэмээн Леголас баяртайяа хэлээд – Алтан ой эндээс эхэлж байна. Хавар биш байдаг нь гачлантай!

Зам харанхуй ой руу шургаж, өндөр өндөр мөнгөлөг саарал модод сэрчигнэх навчсынхаа алтлаг давхаргаар одот тэнгэрийг хаав.

- Чиний зөв, - гэж Арагорн баярлан батлаад – энэ бол үнэхээр Алтан ой, Гэндальфын төлөвлөснөөр бид энд хоноглож болно. Тэр эльфүүдийн эзэмшил газарт орхууд биднийг мөрдөж зүрхлэхгүй гэж бодож байсан юм.

- Эльфүүд хязгаар нутгаа Дайсны хар үүлнээс хамгаалж чадсан болов уу даа? – гэж Гимли эргэлзэв.

- Балар шугуйн эльфүүд Лориэнд олон арван жилээр ирээгүй, гэхдээ манай удам нэгтнүүд маань Харанхуйн хөшгийг амжилттай тогтоож байгаа гэж би сонссон, харин эзэмшил газар нь нэлээд хумигдсан гэнэ лээ.

- Тийм ээ, тэдний эзэмшил газар нь нэлээд хумигдсан – гэж Арагорн хэлээд, ямар нэг зүйл сэргээн санасан мэт санаа алдаад – Тэд Лориэны гүн рүү ухарсан, өнөөдөр тэдний тусламжид найдаж хэрэггүй. Жаахан урагшлаад хоноглоход тохиромжтой хонхор ольё - гээд Арагорн эргэж замаар алхахад Боромир байрнаасаа хөдөлсөнгүй.

- Энэ ойг тойроод явж болохгүй юу? – гэж тэр асуулаа.

- Тойрохий? Яах гэж? - Арагорн гайхав.

- Нууц жим дээрх гэнэтийн гай ил зам дээрх ил дайснаас ямагт илүү аюултай байдаг. Гэндальфын зөвлөснөөр бид Мориин руу орсон... одоо ч бас үхэх гэж яараад байна уу? Лориэний ойгоос амьд гарах амаргүй, байснаараа гараад ирэх боломжгүй гэж Лориэний тухай Гондорт ярьдаг юм!

- Зөв л ярьдаг юм байна. Харин зүйр үгийн утгыг мартсан бололтой, тиймгүй сэн бол

гондорчууд Лориэнээс айхгүй байсан. Гэхдээ яалаа ч гэсэн Андуин руу зөвхөн ойгоор л явж хүрнэ – хэрэв чи буцаад Мории руу орох юм уу, Баразинбар өөд авирах гээгүй л бол энэ л замаар явна.

- Мэдээж хүсэхгүй, тиймээс чамайг дагаад ойгоор явна, харин бас л аюултай зам гэдгийг санаарай!

- Аюултай, - тэгэхдээ хорон муу санаатанд, бас хорон муу санаатанд үнэнчээр үйлчлэгчдэд аюултай. Харин одоо урагшаа, бид цаг алдаж байна шүү.

Аянчид нэг лиг ч яваагүй байхад зүүн талаар шоржигнож байсан Мөнгөлөг голын чимээг баруун талд шуугих хүрхрээний чимээ дарав. Гучаад алхам яваад тэд замын саарал зурвасыг тасалсан голын урсгал эргүүлэг үүсгэн байхыг харав.

- Энэ чинь Цагаан дэл үү? - гэж Леголас дуу алдсанаа – энэ голын тухай олон дуу зохиогдсон, умардын ойн эльфүүд тэр дуунуудыг одоо болтол дуулдаг, бид энэ голын хүрхрээнүүдийн цагаан дэл мэт хөөс, өдөр нь солонгын өнгөөр алаглаж, шөнө нь гүн хөх болдог урсгал, мөнгөлөг, хар болж харагддаг гүн ёроолыг мартаж чадаагүй юм. Гэвч нэгэн цагт амьдрал буцалж байсан Цагаан дэлийн хөвөө аль эрт эзгүйрсэн. Цагаан гүүрийг нурааж, эльфүүд орхуудад түрэгдэн дорно зүг ухарсан. Намайг хүлээж байгаарай, би гол руу буугаад ирье, энэ голын ус уйтгар гунигийг хөөж, ядаргаа тайлдаг гэж ярьдаг юм.

Эльф дайчин эгц эрэг рүү буугаад, гол руу орсноо: - Энд гүнзгий биш байна! Та нар буугаад ир! Өмнөд эрэгт гарья. Тэнд хоноглоход тохиромжтой газар харагдаж байна. Цагаан дэлт хүрхрээний чимээнд бид сайхан зүүд зүүдлэх ч юм билүү - гэж хашгирав.

Аянчид Леголасын хойноос буув. Фродо сэрүүхэн усанд ороод уйтгар гуниг, ядаргаа, айдас илбэдсэн мэт алга болохыг мэдрэв.

Хадгалагчид голыг аажуухан гаталж (голоос гармааргүй санагдаад байв), баруун эрэгт гарч, хоолоо хийгээд тайван идэж, Леголас Кветлоризний тухай домог ярьж өглөө.

Тэр дуугүй болоход шөнийн нам гүмд хүрхрээний нэгэн хэвийн шуугиан сонсогдсоор аажмаар тэр шуугианд ямар нэг гунигт дуу дуулж буй эльфүүдийн хоолой ялгарч байх шиг санагдав.

- Энэ голыг Цагаан дэл гэж хүмүүс нэрлэсэн юм, эльфээр бол Нимродэль гэдэг, цагаан үст бүсгүй гэсэн үг л дээ. Энэ голын тухай нэг гунигт дуу байдаг юм, энэ дууг манайхан зохиосон учир бид умардынхаа аялгаар дуулдаг, Элрондын эльфүүд ч бас дуулдаг, - Ийм дуу байдаг юм:

Өглөөний найдварын туяа мэт,

Үүрийн цолмон од мэт,

Өмсгөл нь алтаар хүрээлсэн мэт-

Өнгө гэрлээр солонгорч,
Бүрхэг өдрийн өмнөх
Бүтэн сар шиг гэрэлтэн,
Бүдгэрсэн цагийн тоосноос
Бүрэн Кветлориэнийг хадгалж,
Саруул уудам талдаа
Салхин адил дураараа
Намар хаврын цагтаа
Навчис адил туяатай
Мөнгөлөг голын дээгүүр
Нимродэль зугаалахад,
Шувуудын жиргээ шиг инээд нь
Шугуй дундуур цангинана.
Гэвч саарал тоос
Гишгэсэн мөрийг нь баллаж,
Ууланд төөрсөн бүсгүй
Ул мөргүй болжээ.
Эргэж ирэхгүй түүнийг
Эргийн хясааны цаана
Энгүй олон хоногоор
Эльф хөлөг нь хүлээжээ.
Нэгэн шөнө гэнэт
Нижигнэсэн аадар шаагиж,
Нүргэлсэн аянга бууж,

Хүчит хар салхи

Хөлгийг өмнө зүг туужээ.

Хөөсрөх давалгаан дунд

Хөшиглөх манан дунд

Хөлөг онгоц өглөөгүүр

Хадан уул мөргөжээ.

Хөлгийн залуурч Элрос

Хөлгүй ус руу үсэрч,

Үсээ салхинд дэрвүүлэн

Өмнө зүг рүү хөвжээ.

Өрнө, дорно хоёр гэвч

Өнгөрсөн явдлыг дурсдаггүй,

Өнөөх далайч ирсэн эсэхийг

Өнөө хэн ч мэддэггүй...

Леголас гэнэт дуугүй болов.

- Цааш нь би дуулж чадахгүй нь, - гэж тэр хэлээд: Энэ бол тэр дууны зөвхөн эхлэл нь, харамсалтай нь би цааш нь цээжээр мэдэхгүй. Маш их гунигтай дуу. Морийнхон мифрил олборлож байгаад хар хүчийг санамсаргүй сэрээхэд Кветлориэн уй гунигт автагдсан, Нимродэль Цагаан ууланд амь үрэгдсэн тухай өгүүлдэг юм...

- Гномууд ямар ч нүгэлт муу үйл хийгээгүй – гэж Гимли түүний үгийг таслахад:

- Тийм ээ, би ч гэсэн гномууд муу үйл үйлдсэн гэж хэлээгүй, би хар хүчийг санамсаргүй сэрээсэн л гэж хэлсэн. Хар муу үйл Мөнхийн настнуудын өмнө хүчгүй, гэвч түүнийг сэрсний дараа олон эльфүүд Кветлориэнийг орхихоор шийдсэн, Тэнгис рүү явах замд Нимродэль амь үрэгдсэн...

Нимродэль лориэний бусад эльфийн адил аварга том модны оройд суудаг байсан гэж ярьдаг, Кветлориэны эльфүүдийг галадриэмм буюу модныхон гэж нэрлэдэг нь дэмий хэрэг биш байх аа. Лориэний гүн ойд ховорхон аварга модод байдаг тул одоо ч гэсэн тэд модон дээр амьдардаг байж магадгүй.

- Модны оройд гараад суучихвал хамаагүй тайван байх сан - гэж Гимли хэлээд, Манант уулын зүг харж - Би орхуудтай тулгарвал лав баярлахгүйдэг - гэв.

- Гимлийн зөв шүү, - гэж Арагорн хэлэв: - Бид замын яг дэргэд сууж байна, гүехэн гол орхуудыг саатуулахгүй. Модон дээр гарах гэж оролдох хэрэгтэй.

Хадгалагчид зам руу эргэж очсонгүй, голын баруун эргээр баруун зүг эргэж, ойн гүн рүү орлоо. Мөнгөлөг, Цагаан дэл хоёрын уулзварыг өнгөрөөд асар өндөр хэсэг модон дунд ороод Леголас зогсч, нөхөддөө хандан:

- Та нар хүлээж бай, би модонд авираад орой нь ямар байдгийг хараадахъя. Тэнд хонож болох ч юм билүү? Би энэ аварга моднууд дээр сууж дасахгүй... гэхдээ мэллорн хэмээх аварга нарсны тухай эртний домгоос сонссон.

- Чи яах юм бэ, би мэдэхгүй – харин би үлгэр домгийн ч бай, ямар ч модон дээр унтаж чадахгүй, би ямар шувуу биш дээ! – гэж Пин хэлэв.

- Тэгвэл чи нүх ух, - Леголас Пинд хэлэв: - Харин чи орхуудаас амиа аваръя гэж бодож байгаа л бол цаг алдалгүй гүнзгийхэн ухаарай! – гээд Эльф дайчин дээш үсэрч нэг том мөчрөөс барьж аваад... тэр дорхноо тавьж, газарт буув. Учир нь модны оройгоос хэн нэгэн захирангуй дуугаар:

- Дара! – гэж хашгирав.

- Өчүүхэн ч бүү хөдөл, - Леголас нөхдөдөө шивнэн анхааруулав. Дээр дуулах мэт аялгуут инээд сонсдоод хэдэн ойлгомжгүй үг аяархан хэлэв. Леголас тэр хэлээр нь хэдэн үг хэллээ.

- Тэр хэн бэ, юу гэж байна? – гэж Пин асуухад Сэм:

- Эльф! – дуу хоолой нь ямар байгааг чи сонсохгүй байна гэж үү?

- Тийм ээ, энэ эльф байна, - гэж Леголас батлаад – Тэр лориэн аялгаар ярьж байна. Түүний хэлснээр бол чи их чанга амьсгаадаж байгаа учир харанхуйд шагайж байгаад харвасан ч алдахгүй гэж байна. Сэм айсандаа амьсгаа нь зогсчих шиг болов. Тэр хооронд лориэн дахин хэдэн үг хэлэв.

- Тэр ингэж хэллээ. Бид нар найзуудынхаа дэргэд байгаа учир айх юм байхгүй – хэмээн Леголас орчуулж, -... Тэр миний дуугаар умардын эльф гэж таньсан байна... Фродог ч мэдэж байгаа гэнэ... тэр Фродо бид хоёрыг дээшээ гарч ирээд танилцацгаая гэж байна... Бусад нь доороо хүлээж бай гэлээ.

Дээрээс олсон шат буулгалаа. Нарийн ширхэгт жоншоор хийсэн тэр олс ер бусын бат бөх болохыг хадгалагчид дараа нь мэдсэн юм. Леголас шатаар бараг гүйх шахам гарахад, Фродо удаан бөгөөд болгоомжтой өгсөв. Эзнийхээ араас үнэнч Сэм нь өгсөхдөө аль болохоор чимээгүй амьсгалахыг хичээж байв.

Аварга нарсны доод талын мөчрүүд тал тал тийшээ болон дээшээ ургасан байх бөгөөд дээрээ

гол ишээ тойрон аварга том цэцэг мэт болж, асар том талбайг үүсгэсэн байна. Тэр талбай дээр лориэнчуудын хэлээр дэлонь гэдэг мөнгөлөг өнгөт тавцан байна, түүний голд олсон шатаар орох хаалга гаргажээ.

Дээшээ гарч ирсэн Фродо, Сэм хоёр мөнгөлөг харанхуйгаас гэнэт урган гарч ирсэн гурван эльфийг харлаа. Тэд сууж байхад модны өнгөтэй цув нь огт харагдуулдаггүй ажээ. Эльфүүд амьсгаадсан хоёр хоббит руу хүрч ирээд нэг нь нийтийн хэлээр:

- Лориэнд тавгай морилогтун, найз нар минь. Бид зочин ховорхон хүлээж авдаг, нийтийн хэлийг бараг мартчихжээ. Тэр хэлийг манай тагнуулчид л сайн мэднэ, учир нь тэд байн байн Ойгоос явж, дайснуудын байдлыг тандаж, Дундад газрын сүүлийн үеийн мэдээг авчирдаг юм. Манай умардын төрлүүд маань хүртэл Лориэнд ирэхээ болиод их удаж байна. Би бол тагнуулч. Миний нэр Хэлдар. Миний хоёр дүү Орофин, Рамил хоёр нийтийн хэлийг бараг мэдэхгүй.

Эльфүүд өөрсдийнхөө нэрийг сонсоод, хүндэтгэн мэхийсэн боловч дуугарсангүй.

- Та нарын тухай Элрондын элч нар бидэнд дуулгасан, Дундад газрын баруун хойт хэсэгт хаа нэгтээ намхан хүмүүс амьдардаг, өөрсдийгөө хоббитууд гэж нэрлэдгийг сонссон. Бид харийнхныг нааш нь оруулдаггүй, гэвч та нарыг манай умардын садан маань батлан дааж байгаа, батлан даагаагүй ч гэсэн та нар муу үйлтнүүд биш гэдэг нь харагдаж байна, тиймээс бид Элрондын хүссэнээр Андуинд хүрэхэд тусална. Өнөө шөнө энд хоноод, маргааш Төлөгч голоор гаталж цааш явна. Танай отрядад хэдэн дайчин байгаа вэ?

- Найм, энэ хоёр, өөр хоёр хоббит, хоёр хүн, нэгийг нь та нар мэдэх байх – Арагорн, умардын мөрч гэж Леголас Хэлдарт танилцуулав

- Тийм ээ, Араторны хүү Арагорн, Лориэнд өөрийн хүн - гэж Хэлдар батлаад – Манай Хатан хаан бидэнд түүний тухай ярьсан. Харин чи долоон хүний нэр л хэллээ.

- Найм дахь нь - гном.

- Гном гэв үү? - хэмээн Хэлдар хөмсөг зангидаад – Бид гномуудтай хамтардаггүй. Хар жилүүд бидний холбоог тасалсан. Би түүнийг Лориэнд оруулж чадахгүй.

- Гэвч Дайны хаант улсын энэ гномыг Элронд өөрөө хадгалагчдын багт томилсон юм шүү дээ – Фродо Хэлдарыг ятгахыг оролдов.

Хэлдар дүү нартайгаа зөвлөлдөж, Леголасаас хааяа ямар нэг юм асууж, Леголас лориэн аялгаар хариулж байсан тул юу ярьсныг нь Фродо ойлгосонгүй. Эцэст нь Хэлдар хоббитуудад хандаж:

- За яахав, би би заншлаа зөрчиж, энэ гномыг Лориэнд оруулья, Арагорн, Леголас хоёр түүнийг нүд салгахгүй ажиглана гэж амлаж байгаа юм бол яая гэхэв. Гэхдээ бид голоор гаталсны дараа түүний нүдийг бооно - гээд Эльф түр дуугүй сууснаа ажил хэрэгч дуугаар: - Одоо яриагаа дуусгая. Орхууд Мориид аль эртнээс цувж байна, - тэгэхлээр та нарын араас

орхууд хөөж яваа. Бид үүрээр хөдөлнө. Хоббитууд эндээ унтана. Хүмүүс болон гном хажуугийн нарсан дээр унтана, тэнд бас нэг дэлонь байгаа. Чи тэднийг хариуцна шүү, Леголас! Бид гномуудад ч, хүмүүст ч итгэдэггүй.

Леголас Хэлдарын даалгаврыг биелүүлэхээр чимээгүй буув. Удалгүй чангаар амьсгаадсаар Мерри, Пин хоёр тавцан дээр гарч ирэв. Хоёулаа л тавгүй байгаа бололтой.

- Та хоёрын хөнжлийг аваад ирлээ. Бусад ачааг Тэнэмэл хонхорт нуугаад бөөн навчаар хуччихсан - гэж Мерри жаахан амьсгаа дарсныхаа дараа хэлэв.

- Дэмий л чирч гарч ирж дээ, мэллорны оройд өвөл сэрүүхэн байдаг, манайд нөөц хөнжил, үстэй дулаан хувцас байгаа. Хоёр голын уулзвар энэ газарт байнгын харуулын байр байдаг юм – гэж Хэлдар хэлэв.

Хоббитууд хоёр дахь удаагаа оройн хоол /маш сайхан хоол байсан/ идэхээс мэдээж татгалзсангүй, хооллочихоод үстэй цув өмсч, өөрсдийнхөө болон эльфүүдийн хөнжлөөр давхарлаж хучаад унтах гэсэн боловч огт болдоггүй! Хоббитууд өндөрт гарах дургүй, ийм өндөрт унтаж үзээгүй, тэдний нэг давхар сууцанд угаасаа дээд давхар гэж байхгүй, аварга модны орой дээрх тавцанд хана байтугай хашлага ч байхгүй, зөвхөн салхи хаадаг зөөврийн сүлжмэл хаалт л байна. Ийм унтлагын өрөөнд яаж унтах билээ!

- Газар унтах юмсан - гэж Пин бувгнав.

- Хэрэв би унтчих юм бол сэрэхгүй, газарт унасан ч сэрэхгүй... Ийм өндөрт яаж унтах юм бэ? – гэж нойрмоглох хэлэж дуусав уу, үгүй юу хурхирч гарав.

Фродо харанхуй руу харан юу ч бодолгүй хэсэг хэвтэв. Хажууд нь Сэм тайван унтаж, тэнгэрт бүдэгхэн одод ирмэлцэн, тавцангийн захад шөнийн харанхуйд эльфүүд үзэгдэхгүй шахам сууна.. Хоббит хоёр харуулыг л харлаа, гурав дахь нь доошоо буусан бололтой. Фродо нүдээ аньж, навчсын сэржигнээнд бүүвэйлүүлэн унтав.

Тэр үүрээр сэрэв. Нөхөд нь унтаж байна. Тавцан дээр нэг ч эльф алга. Хавирган сар цайвартан харагдаж байна. Алсад сөөнгө хоолойгоор ярилцах сонсдож, туурайн жигдхэн чимээ, төмөр хангир жингэр дуугарах сонсдов. Тэр чимээ чангарсаар бүр тод болов....

Гэнэт хавтангийн нээлхийгээр юүдэнтэй толгой цухуйхад Фродо босон харайв. Тэр эльф байлаа.

- Юу болов? - гэж Фродо шивнэхэд

- Ирчи!- гэж эльф товчхон шивнээд эвхсэн шатаа хавтан дээр хаялаа.

- Орхууд уу? - гэж Фродо шивнэн асуухад эльф, юу ч хэлэлгүй доош буув.

Туурайн чимээ зүүн хойт зүг рүү тачигнан одов. Ойд нам гүм боллоо. Модны навчис ч чимээгүй, хүрхрээний чимээ ч байдаггүй. Фродо хөнжлөөрө хучаад суув. Орхууд биднийг газарт гүйцээд ирээгүй нь яамай... гэвч нарс мод найдвартай хамгаалалт мөн үү? Орхууд

мэдрэмж сайтайгаараа цуутай, тэгээд бас модонд авирахдаа муугүй. Фродо Тернийг хуйнаас нь сугалахад ир нь хурц гэрэл цацруулаад тэр дорхноо бүдэгрэв. Гэлээ ч гэсэн Фродо сэтгэл түгшсэн хэвээр, харин ч нэмэгдсээр байв. Тэр босч, тавцангийн нээлхийгээр доош болгоомжтой харав. Тэр юу ч олж үзээгүй боловч өвс, навчны сэржигнээнээс өөр нэг чимээ сонсов.... Эльфүүдийн алхаатай ч адилгүй, эльфүүд чимээ гаргалгүй алхдаг. Фродо амьсгаагаа түгжин чагнав. Тийм байна, хэн нэгэн дээш авирч байна Фродо харанхуй руу нүд цавчилгүй ширтэв...

Тэгээд гэрэлтэж байгаа нүд харлаа. Дээш авирч байсан этгээд нам жим болж, доор ямар ч чимээгүй боллоо, харин нүд Фродо руу эгцлэн ширтэж байна. Фродо давхийн цочив. Нүд алга болж, мөнгөлөг модны голоор бүдэг сүүдэр гулсан, шир ширхийсэн чимээ бүдгэрсээр тасрав...

Харанхуй дундаас Хэлдар гэнэт гараад ирэв. Тэр мөчирт бараг хүрэлгүйгээр хөнгөхөн авиран гарч ирээд:

- Та нарыг нэг хачин этгээд дагаад байна. Тэрнийг би бүр газарт байхад нь харсан юм. Тэр бас намайг харсан байх, тэгээд л зугтаачихлаа. Гэвч энэ бол орх биш. Эхлээд би тэрнийг та нарын нэг гэж бодсон юм. Намхнуудын нэг нь газарт буучихаж гэж. Тэр намхан юм билээ. Та нар яалаа гэж надаас зугтаах билээ, тэгээд л би дайсан гэж бодлоо. Гэвч би тэрнийг харвасангүй, сум тусахаар хашгирч магадгүй, орхууд холдож амжаагүй байгаа.

Тэд Мориин талаас орж ирсэн, муусайн нохойнууд гол гатлаад өмнөд эргээр удаан шиншилсэн, та нарыг хаашаа эргэснийг мэдсэн бололтой. Зуун тавиас цөөнгүй юм байна. Бид тэднийг буцааж хүч хүрэхгүй учир би харуулын байрандаа үлдэж, Рамил та нарыг дуурайж дуугаран, тэднийг чулуу хөөлгөж, Нууц шугуй руу дагуулж явсан, Орофин манайхан руу тусламж дуудахаар явлаа.

Одоо ойгоос нэг ч орх амьд гарахгүй. Маргаашнаас эхлэн баруун хил дээр хилийн отрядууд ирнэ. Унтаж бай. Бид өглөөгүүр Стэрр руу хөдөлнө.

Өвлийн цагаан нар аварга нарснуудын навчис дээр алтран тусч, өглөө сэрсэн хоббитуудад алсын төрөлх нутгийг нь санагдуулав. Баруун зүгт навчсын завсраар Цагаан дэлийн нарийхан хөндий олон хүрхрээнийхээ хөөсөрсөн шаттай харагдана. Баруун хойт зүгт Мөнгөлөг гол гялалзан харагдах ба Алтан Төлөгч голыг модод хааж байв. Хадгалагчид замд гарахад түргэн зуурт бэлтгэв.

- Баяртай, Нимродэль, - гэж Леголас хэллээ.

- Баяртай, - гэж Фродо хэлээд тайвшруулагч дуу чимээ, ангаагч устай ийм гайхамшигт голыг хэзээ нэгэн цагт дахиж харах болов уу гэж бодлоо.

Хэлдар тэднийг Төлөгч голын хөвөөгөөр дагуулан явахад удалгүй Рамил ирлээ.

- Та нарыг мөрдөгчид Нууц Шугуйд орой болтол тэнэж төөрнө, тэдний нэг нь ч нутаг буцахгүй, энэ талаар Лориэний дайчид санаа тавина – гэж тэр хэлэв.

Гурван лиг орчим яваад Хэлдар зогсч, Алтан Төлөгч гол руу хараад хоёронтоо шувуу шиг аяархан исгэрэв.

- Нөгөө эрэгт харуулын хоёрдугаар цамхаг байдаг юм – гэж тэр хадгалагчдад тайлбарлав.

Моддын дундаас өнгөлөн далдлалтын цувтай эльф харуул гарч ирлээ. Хэлдар хуйлж эвхсэн мөнгөлөг аргамжийг гайхалтай урнаар нөгөө эрэг рүү шидлээ.

Эльф харуул аргамжийг шүүрч аваад модонд уяв.

- Төлөгч энэ хэсэгтээ маш гүнзгий, хүйтэн, манай энэ түгшүүрт үед байнгын гүүр барих аюултай. Бид голоор яаж гардгийг харцгаа – гэж Хэлдар хэлэв.

Эльф харуул аргамжийн нөгөө үзүүрийг модонд ороож, чангалан татаад бат бэх уялаа. Дараа нь яг л замаар явж байгаа юм шиг тайван голоор гатлаад эргэж ирэв.

- Миний хувьд энэ бол ердийн зүйл, харин бусад маань яах бол? Тэд сэлж гарах юм гэж үү?

- Яагаад сэлэх билээ? Бидэнд дахиад хоёр аргамж байна. Бид түрүүчийн аргамжнаас арай дээгүүр хоёрыг татна. Тэгээд л танай нөхөд гарна даа.

Энэ өвөрмөц гүүрээр Хадгалагчид хойт эрэгт гарсан ба зарим нь удаан, арай ядан гарсан бол зарим нь арай түргэн гарав. Хоббитуудаас хамгийн гавшгай нь Пин байсан ба тэр зөвхөн нэг аргамжнаас бариад хангалттай итгэлтэйгээр алхаж гарсан боловч ус руу харахгүйг хичээв. Сэм хоёр аргамжнаас хоёр гараараа барьж, алтлаг шаргал уснаас нүдээ салгалгүй удаан алхаж гарав. Эрэг дээр гараад тэр санаа амран, гүн санаа алдаад:

- Миний аав “зуун жил амьдарвал зуун жил сур” гэж хэлдэгсэн. Гэхдээ тэр насаараа газартай ноцолдсон болохоос биш аалз шиг аалзны шүлснээс зууран мөлхөж байгаагүй л дээ – гэв.

Рамил өмнөд эрэгт үлдэж, бүгдийг гаталсны дараа аргамжуудаа эвхэж аваад, гараараа даллан салах ёс хийгээд өөрийнхөө харуулын байр руу алхаж одов.

- Ингээд найзууд минь, та нар Стэрра буюу та нарын хэлээр Лориэний зүрхэнд ороод ирлээ – гэж Хэлдар ёслол төгөлдөр зарлаад – Энэ эрэгт гарсан нь цөөхөн дөө... гээд - Хэлдар нэгэн мөч чимээгүй болсноо ердийн байдлаар: - Одоо бид гномын нүдийг бооно, би энэ тухай Леголаст хэлсэн. Бусад нь ойн цайз хүртэл нүдээ боолгохгүй явна.

- Леголас миний өмнөөс шийдэх ёсгүй байсан юм даа – гэж Гимли царайгаа барайлган хэлээд – Би олзлогдогч биш. Сауроны тагнуул биш. Дайны Уулын хаант улс хэзээ ч Дайсантай холбоотон байгаагүй. Чи яагаад намайг хорон муу үйлтэн гэж бодоов?

- Хэрэв би чамайг хорон муу үйлтэн гэж бодсон бол эртнээс нааш мөрдөж ирсэн хуулиа зөрчих байсан уу? Хуулиар бол би Стэррад нэвтрэхийг оролдсон гномыг устгах байсан. Чи миний тусламжаар гол гаталсан биз дээ?

- Би нэг бол нүдээ боолгохгүй явна, эсвэл хэн ч намайг тагнуул гэж нэрлэдэггүй Уулын хаант

улс руугаа явна - гэж Гимли бардамаар хариулаад арагш ухарч сүхнийхээ бариул дээр гараа тавилаа.

- Чи Алтан Төлөгч голыг гаталснаар буцах замаа хаасан. Би чамайг Эздэд хүргэж өгөх ёстой, чамайг яахыг тэд мэднэ биз. Чи голоор сэлж гарахыг оролдвол хамгийн түрүүнд харсан харуул нам харвана.

Гимли бүснээсээ сүхээ сугалав.

Хэлдар цахилгаан мэт хурдан хөдөлгөөнөөр сумаа гарган нумаа татав, хоёр дахь эльф ч түүнээс хоцорсонгүй.

- Хараал идсэн хар зөрүүд – гэж Леголас аргаа барсан байртай хэлэв.

- Гимли, бүү хөдөл! - гэж Арагорн тушаахад Гимли хөшөө мэт нам зогсов. Арагорн: - Багийг би удирдаж яваа, та нар миний үгийг дагах ёстой. Ганцхан Гимлийн нүдийг боох юм бол Гимлиг шударга бусаар доромжилсон хэрэг болно. Тиймээс бүгдээрээ нүдээ боолгоод явъя..., тэгэхдээ маш удаан л явах болно доо.

- Тэгвэл бид ёстой гоё харагдах юм байна даа - гэж Гимли гэнэт тачигнатал инээгээд – Алтан ой дахь галзуучуудын марш.. Би Леголастой хамт галзуугийн дүрд тоглоход бэлэн байна, бусад нь үзэгч болно биз – гэж хөгжилтэй хэлэв. Леголас:

- Чи гном, би бол ...

- Зөрүүд үү? - гэж Арагорн ёжтой асуугаад, - Ерөөсөө л шударга ёсоор шийдье. Алив миний нүдийг боогоодох! – гэж Хэлдарт хэлэв.

- Хэрэв би бүдэрч унах юм бол миний биед үүссэн шалбархай бүрийг чи харицна шүү - гэж гном дайчин нүднийхээ боолтыг тэмтэрч үзэнгээ Хэлдарт хэлэв.

- Унахгүй ээ, манай Лориэний зам гайхамшигтай сайн – гэж нөгөөдөх нь итгэлтэй хэллээ.

- Мөн ч хачин цаг ирж дээ. Бид бүгдээрээ ганцхан Дайсны дайснууд, тэнгэрт нар мэлтийж байхад би өөрийнхөө садан төрлийнд ирчихээд сохор юм шиг тэмтэрч явах нь – гэж Леголас үглэв.

- Хачин аймшигтай цаг. Бидний тархай бутархай байдал, харилцан үл итгэлцэх нь Дайсны хорон муу санаа, үнэхээр агуу их хүчнээс үүдсэн юм. Лориэнчүүд биднээс хичнээн удаа урвалаа, бид Уудам хөндийн удам нэгтнүүдээсээ өөр бараг хэнд ч итгэхээ больсон, - Манай нутаг тал бүрээсээ дайсанд бүслэгдсэн арал болж хувирлаа. – гэж Хэлдар хэлээд хэсэгхэн зуур дуугүй байснаа: - Харанхуйн хөшиг улам л тэлж, улам л бэхжиж байна. Тэр хүч Лориэний дээгүүр бүрхэж чадахгүй боловч, хүчирхэг хар жигүүр нь биднийг зүүн, баруунаас хавчиж байна. Одоо бид явахгүй бол Тэнгист хүрч чадахгүй. Манант уулыг орхуудын арми эзэлсэн. Бөглүүд шугуйд сүрэг сүргээрээ чонодолдоохууд шиншилж явна. Одоо Ристани харанхуйд хучигдаж, Дайсан их мөрөнд тулж ирсэн гэгцгээж байна. Тэгэхлээр эльфүүдийн

чөлөөт буудал нь зөвхөн зүүн хойт зүгт, Мөнхийн ой, намхануудын газар л болж байна.

- Тийм ээ, манай газраас баруун тийш эльфүүдийн тэнгисийн суурингууд байдаг гэж Мерри чухал царйлан өгүүлэхэд:

- Жаргалтай ард түмэн, баруун боомтуудад ойрхон амьдардаг! Бид аль дивангарын эринээс хойш тэнд очоогүй. Надад тэдний тухай ярьж өгөөч - гэж тэр хоббитоос гуйв.

- Би очиж үзээгүй, - гэж Мерри үнэнээ хэлээд – Урьд нь надад аялах боломж гарч байгаагүй юм. Хэрэв би дэлхий дээр юу болж байгааг мэдэж байсан бол Хоббитанаас гарахгүй байх сан.

- Имладрис юм уу, Кветлориэнийг үзэхгүй байсан гэж үү? - гэж Хэлдар асуугаад – манай өнөөгийн ертөнц хатуу бөгөөд аюултай, зарим чөлөөт газар Дайсны хар сүүдэрт хучигдсан, хайр харамслаар дуусах нь олонтаа байдаг, гэхдээ үүнээсээ үүдээд улам сайхан болдог.

Эльф үгээ түр тасалснаа гунигтай төгсгөв: - Харанхуйн хөшиг яваандаа бүр Мордорыг нөмөрч, ор мөргүй алга болно гэж олон хүн боддог... Би үүнд итгэдэггүй. Ертөнц хэзээ ч урьд өмнөхөөрөө байхгүй, нар хэзээ ч урьдынх шигээ хурц байхгүй. Түр зуурын гэгээрэл байж болох юм, тэгвэл эльфүүд бид Дундад газрыг бүрмөсөн орхиж, тэнгист хүрнэ... бид Лориэнийг орхиж, мэллорны байдаггүй газарт амьдарна гэж үү? Эльфийн домогт итгэх юм бол Тэнгисийн цаана Алтан ой гэж байхгүй шүү дээ. Тэнд бид яаж амьдрах юм, мэдэхгүй юм даа!

Хадгалагчид галуун цуваагаар гэлдэрч явна. Цувааны түрүүнд Хэлдар яаралгүй алхаж, хоёр дахь лориэн дайчин хамгийн сүүлд явж байна. Зам нь хөлд зөөлөн, тэгшхэн байхыг бодвол элс бололтой, төдөлгүй аянчид итгэлтэй алхдаг болов. Нүдээ боочихоод явж байгаа болохоор тэр юм байлгүй, тэдний мэдрэхүй маш хурц болжээ. Фродо өвөл болж хатсан ч гэсэн амьтай хэвээрээ байгаа өвсний үнэрийг мэдэрч, нарсны навч шивнэлдэх, шувуудын яриа, горхины шулганаан, их уст Төлөгч голын тайван харгиаг сонсч байв. Тэд ойн цоорхойгоор явж өнгөрөхөд Фродо хацраараа нарны гэрлийг мэдэрч байв.

Төлөгч голын дээгүүр явж байхад гэнэт тэр голын дээгүүр тавьсан аргамжин гүүр гурван эриний дээгүүр өнгөрч, өнөөгийн ертөнцөөс тасран аль дивангарт өнгөрсөн анхдагч эринд хүрч байгаа юм шиг санагдсан билээ. Стэррад энэ хачин мэдрэмж нь улам хүчтэй болжээ. Нүдээ боосноос ч юм уу, түүний эргэн тойронд өнгөрсөн эрин амь орж байгаа мэт сэтгэгдлээс салж чадахгүй байв. Уудам хөндийд бүх юм өнгөрсөн үеийг санагдуулж байсан бол энд бүх юм амьд бөгөөд бодитой, хар хорон санаа, хорт муу үйл, уйтгар гуниг умардын эльфүүдийн өмнө хүчгүй боловч Уудам хөндийд тулж ирээд, харин Лориэн тэр бүхэн хараахан төрөөгүй үед амьдарч байгаа мэт санагдана.

Хадгалагчид Хэлдарын араас амралтгүй алхсаар, мэдэгдэхүйц сэрүүссэн салхи тэдэнд үдэш болж байгааг мэдээлж байлаа. Тэд хоолоо идэж аваад, умрын салхинаас бутнуудаар халхлагдсан зөөлөн нугад хөнжлөө нөмрөөд унтлаа. Хэлдар нүдний боолтоо авахыг зөвшөөрөөгүй учир модонд авирч чадсангүй, орхуудын талаар яагаад ч юм огт санасангүй. Өглөө эртлэн замаа хөөсөөр үд өнгөрсөн хойно амрахаар зогсов. Хоолоо идээд хөдлөх гэж

байтал гэнэт эльфүүдийн дууг сонсов.

Ойн баруун хойт захаар эльфүүдийн нэлээд том баг явж байсан нь орхууд дахиад Лориэнд орж ирвэл тэдний довтолгоог няцаахаар явж байсан аж. Дайчдын авчирсан зарим мэдээг Хэлдар хадгалагчдад товчхон ярьж өгөв. Тэднийг хөөж явсан орхуудын хүчийг Нууц шугуйд устгажээ. Эльфүүдийн нэг нь хоёр хөлтэй мөртөө араатантай адилхан хачин амьтан харсан бөгөөд түүнийг барьж чадсангүй, гэмгүй араатан байж магадгүй гээд харвасангүй гэнэ, тэр амьтан голын дагуу зүүн зүг рүү зугтсан байна. Хадгалагчид эльфүүдийн ийм хэнэггүй байдалд гайхсан боловч Хэлдар жинхэнэ хорон муу үйлтнүүд Лориэнд зөвхөн олноороо орж ирдэг учир тэр үнэхээр гэмгүй амьтан байжээ гэж тайлбарлав.

- Гэвч гол мэдээг та нар хараахан сонсоогүй байна – гэж Хэлдар хэлээд – Лориэны эзэд та нарыг бүгдийг чинь, гномыг хүртэл нүдээ нээлттэй явахыг зөвшөөрсөн байна. Тэд та нарыг чухам хэн хэн болохыг нэгбүрчлэн мэдэхгүй байгаа бололтой, эсвэл намайг Лориэнд эзгүй үед Элрондаас дахиад элч ирсэн байх – гээд тэр хамгийн түрүүнд Гимлийн боолтыг тайлав. Тэгээд:

- Бүү уурла! Хар жилүүдээс хойш лориэнд нэг ч гном хөл тавиагүй юм. Чамд онцгой өндөр хүндэтгэл үзүүлж байна!

Удалгүй Фродогийн боолтыг ч тайллаа. Тэр нүдээ нээгээд эргэн тойрноо сэтгэл догдлон харав. Хадгалагчид нэг том нугад байна. Зүүн талд нь тод ягаан өнгөт өвсөөр хучигдсан өндөр толгой байна. Толгойн орой дээр эртний моддын хамгийн өндөр нь байсан болов уу гэмээр ихэр хоёр диadem мод байх бөгөөд тэр хоёрийн дунд энэ хоёр аваргаас ч том бас нэг мод ургажээ. Энэ бол мэллорн буюу аваргын аварга нарс бөгөөд алтлаг навчис дээр нь лут том цагаан дэлонь байна. Тэдгээрийн гадуур бас л аварга том, ер бусын шулуун цагаан модод байх бөгөөд бөмбөлөг хэлбэр үүсгэсэн мөчрүүдтэй боловч навчгүй ажээ. Толгойн бэлийн цэнхэр ягаан өнгөт ургамал дунд өвлийн од мэт мөнгөлөг, цэнхэр цэцэг алаглана. Толгодын дээгүүр үд дундын ёроолгүй гүн цэнхэр тэнгэр цэлийж, үдийн нар ээж байв.

- Та нарын өмнө Уй гашуудлын толгод байна – гэж Хэлдар гунигтай ч гэсэн бахархалтай өнгөөр хэлээд – Манай домогт өгүүлснээр, энэ толгойн дор Лориэний анхны эзэн хаан Эмросын бунхан байдаг. Энд ямар ч хатуу өвөл болоход ч цэцэг ногоо нь ганддаггүй. Одоо амарцгаа, орой гэхэд бид манай эздийн өмнө очсон байх болно.

Ядарсан хадгалагчид өвсөн дээр хэвтээд өгөхөд Фродо хэвтэж ч чадахгүй, хөдөлж ч чадахгүй эргэн тойрноо алмайран харсаар байлаа. Тэрбээр үүрд үгүй болсон гэрлээр гийгүүлэгдсэн, өнгөрч сөнөсөн ертөнцийг харж, тэрхүү гайхмаар эртний ертөнц түүний мэл гайхсан харцаар нээгдэж, нүдний нь өмнө шинээр төрж байлаа. Тэр зөвхөн өөрийнхөө мэддэг цэцгүүд, цагаан, шар, ногоон, хөх цэцгүүдийг харж байсан бөгөөд тэр цэцгүүд энэ газарт анх удаагаа ургаж, тэр цэцгүүдэд өөрөө нэр өгсөн юм шиг тийм ер бусын шинэ байв. Энэ газарт зунд нь хаврыг санагалзах юм уу, өвөлд нь зуныг мөрөөдөх хэрэг байхгүй, Ариун хязгаарын өөрчлөгдөшгүй амьдралд өнгөрсөн, ирээдүй хоёр бие биедээ уусчээ.

Фродо санамсаргүй Сэмийг харав – тэр үзсэн зүйлдээ итгэхгүй байгаа бололтой алмайрчихсан, нүдээ дахин дахин арчиж байв.

- Би урьд нь, хэрэв эльфүүд байгаа бол, шөнө... харанхуй ой, сар, одод байгаа гэж боддог байсан юм... Гэтэл хараач хөөе – цагаан өдөр... гэрэлтэйгээс гэрэлтэй, тодоос тод ... Эльфүүдэд яг зохих юм байна! Би өөрөө биш юм шиг, дуунд... хэрэв та миний юу ярьж байгааг ойлговол – хэмээн Сэм бувтнаж байв.

Хэлдар түүн рүү хараад инээмсэглэж, Сэмийн ярьж байгаа юмыг сонсох нь байтугай ойлгож, түүний гүн утга санааг ухаарсан мэт:

- Та хоёр Лориэний хатан хааны хүч чадлыг мэдэрч байна – гэхэд нь хоёр хоббит сайн ойлгосонгүй.

- Эмросын дэлонь дээр гарч үзмээр байна уу?

Хоёр хоббит Толгодын орой дээр гарав. Фродо Хэлдарын араас яаралгүй алхаж явахдаа нэгэн цагт сэвэлзэн үлээж байсан, тэгээд мөнхийн хувиршгүй ертөнцөд орчихсон салхийг нүүрээрээ мэдэрч, эндээс явахад хүрвэл алсын Хоббитаны аянчин тэрбээр энэ амьдралд мөнхөд үлдэх болсноо мэдэрч байлаа.

Тэд төв мэллорнд дөхөж ирэв. Тэгмэгц салхи өмнө зүгээс үлээж, нарсны алтлаг навчсын сэрчигнээнд тэртээ өнгөрсөн эринээс тэнгисийн их давалгаан аль дивангарт алга болсон эрэг рүү түрж байгаа чимээг Фродо сонсч, хязгааргүй их усан мандал дээгүүр Дундад газарт хэний ч хараагүй цахлайнууд халин нисч байхыг үзэв.

Хэлдар аль хэдийн дээр гарчээ. Фродо аргамж шатнаас нэг гараараа барьж, зүүн гараараа мэллорн модыг түшихэд – модонд цохилж байгаа шинэ амьдрал урьд өмнө нь хэзээ ч бүрэн нээгдэж байгаагүйгээр нээгдэв. Тэрбээр модны зөөлөн арьс-холтос, асар хүчирхэг мөртөө арчаагүй модны махбодыг мэдэрч, тэр нарстай төрөл барилдсан мэт болов.

Дэлонь дээр Хэлдар түүний гараас татаж гаргаад өмнө зүг рүү эргэж:

- Юуны өмнө тийшээ хар! – гэж захирангуй хэлэв.

Фродо өмнө зүг рүү дуулгавартай хараад, нэлээд холд нэг бол аварга том модод бүрхэн ургасан, нэг бол алтан ганжирт дээвэртэй мөнгөлөг өнгөт цамхгууд тойруулан барьсан багахан уул байхыг үзэв. Тэр уулнаас асар их татах хүчтэй гэгээн хүч цацарч байх шиг, өөрөө гэнэт жигүүртэй болчихсон адил тунгалаг агаарт хөөрөөд тэр ууланд хүрч бүх гай зовлонгоос ангид тайван амрахыг хүсч байгаагаа мэдрэв.

Дараа нь тэр дорно зүг рүү харлаа. Өмнө нь Алтан ой дурайж, их мөрөн Андуинд нийлэхээр Төлөгч гол дундуур нь аядуухан урсч байна. Тэр анхааралтай ажиглаад Андуины зүүн эрэг болон голын зүүн талын намхан нугууд цагаан саарал өнгөөр тодорч байгааг хараад гайхав. Тэнд өвөл ид дундаа байгаа нь илт. Нугын хаа нэгтээд бутнууд бараантаж, тэнгэрийн хаяа руу алсалсан намхан толгод сийрэгхэн ойгоор бүрхэгджээ. Саарал манан дунд жаргах нарны цайвар туяа бүүдгэрч байхад Кветлориэний дээгүүр алтлаг өнгөөр туяарч харагдав. Хэлдар Андуин мөрөн рүү хараад:

- Тэр сийрэг ойн цаахнагай Нууц шугуй үргэлжилж байгаа, тэндхийн ширэнгэд чихэлдэж ургасан гацуур, далдуу модод гэрэл өөд тэмүүлэхдээ өөрийн төрөл төрөгсдөө хайр найргүй хөнөөдөг, чийглэг, халуун газар тэдгээрийн доод талын мөчрүүдийг амьдаар нь илжрүүлдэг юм. Тэр намгархаг өндөр толгой дээр Дул-Гулдурын нэвтэршгүй цамхаг байдаг, тэнд нэгэн цагт Дайсан нэвтэрч орсон, одоо ямар нэг ойлгомжгүй зүйл болоод байгаа юм. Цамхгийн шовх оройтой дээврүүдийнх нь дээгүүр байнга хар үүл бөөгнөрч байдаг, заримдаа аянга цахилгаан гялбаж байдаг, тэр ширэнгэд ямар хүчнүүд тулалдаад байгааг манай хатан хаан хүртэл мэдэхгүй байгаа. Хэлдар яриагаа дуусгаад доош буухад Фродо, Сэм хоёр араас нь буулаа.

Толгойн бэлд Арагорн Эмросын нарс шиг таг дуугүй, хөдөлгөөнгүй зогсч байв. Тэр гартаа нэгэн мөнгөлөг цэцэг барьсан байх бөгөөд нүд нь жаргалтай дурсамжаар гэрэлтэн байв. Газарч нь Лориэний мөнхийн амьдралын ямар нэг аз жаргалтай мөчийг дурсч байгааг Фродо ухаарав. Учир нь Арагорны ширүүн дүртэй баргар царай залуу, сайхан харагдаж, аяны гандмал цув нь нарны гэрэлд алтарч харагдана. Фродогийн өмнө нуменорын ван зогсч байгаа нь энэ билээ. “Ванаи-мэльда, Арвен”, - гэж хэлэхийг нь Фродо сонслоо. Арагорн эргэж хараад хоббитуудыг үзэж:

- Миний зүрх сэтгэл наашаа өөрийн эрхгүй тэмүүлдэг юм – гэж гунигтайхан инээмсэглээд – Хэрэв бидний аялал ялалтаар төгсөхгүй бол, тэр энд үүрд нойрсох болно. Явцгаая! – гээд Арагорн хоёр хоббитын гараас хөтөлж, тэд бусад аянчидтайгаа нийллээ. Энэ амьдралдаа тэр энд дахиад ирээгүй билээ.

Бүлэг 19

Галадриэлийн толь

Хэлдар хадгалагчдыг цааш дагуулан явлаа. Нар Манант нуруу руу хэвийж, дорно талд үдшийн сүүдэр өтгөрөв. Жим нарсан ой руу шургаж, тэнд бараг харанхуй болсон тул эльфүүд бүдэгхэн дэнлүү асаалаа.

Гэвч удалгүй гэгээ орж, хадгалагчид уудам талбайд гарч ирэв. Талбайн өмнө тал аажмаар өргөсч, аянчдын өмнө нэгэн өндөр хана үзэгдэн, түүний наагуур бараг эгц эрэгтэй нэлээд өргөн жалга хөндөлсчээ. Хананы цаана, мөнгөлөг одод ар араасаа тодрон, харанхуйлж буй тэнгэрийн дор аянчид бүр энд, Лориэнд хүртэл хараагүй тийм аварга нарснууд сүндэрлэж байв. Тэрхүү аварга моднуудын мөчрүүд нь модон давхрууд үүсгэх мэт хэдэн үе үүсгэн тойрчээ. Давхар бүрийн өтгөн навчсын завсраар мөнгөлөг, хөх, ногоон, алтлаг өнгө өнгийн олон гэрэл гялалзана. Хэлдар хадгалагчид руу эргэж хараад:

- Энэ бол Галадхэн – Ойн Шилтгээн, энд эрт цагаас Лориэний эзэд сууж байгаа юм! Гэхдээ эндээс Шилтгээн рүү нэвтрэх боломжгүй, учир нь Хаалга өмнө талдаа байдаг. Тэр хүртэл нэлээд явна. Галадхэн агуу – гэлээ.

Жалгын дагуу зургаан талт цагаан шөрмөсөн чулуугаар тавьсан өргөн зам байх бөгөөд зүүн өмнө зүг рүү эргэжээ.

Зүүн талаар, ханын цаагуур Галадхэний олон өнгийн гал гялалзана. Шинэ шинэ гэрэл нэмэгдсээр аянчдыг гүүрэнд дөхөж ирэх үест Галадхэний уул алсын одот тэнгэрийн тусгал мэт санагдаж байв.

Цагаан чулуугаар нуман хаалгатай барьсан гүүр аянчдыг нүсэр өндөр хананд хүргэхэд Хэлдар хана даган зүүн тийш алхав. Гучаад алхам яваад хана төгссөн боловч цаана нь дөрвөн алхам зайтай хоёр дахь хана сүндэрлэж, хоёр ханын хооронд нарийхан хонгил үүсгэжээ. Хэлдар тэр хонгилоор ороод эргэж, аянчид одоо буцаад алхав. Хонгилын эцэст зүүн тийш харсан хаалга байв. Фродо тэр хаалгыг хараад бишрэв. Өмнөд хананд гаргасан хаалга Их Андуин мөрөн рүү харсан байлаа! Яагаад гэвэл эртний уран барилгачид хотыг тойруулан хэрэм барихдаа битүү хүрээ болгодоггүй, хоёр үзүүрийг зөрүүлж дундуур нь нарийхан хонгил гарган үргэлжлүүлдэг байжээ. Тэр хонгилд Хаалга байлаа.

Хаалганы баруун талд модон иштэй, хүрэл гинжтэй алх өлгөжээ. Хэлдар тэр алхаар хаалгыг тогшиж нэг юм хашгиртал нүсэр том хаалга чимээгүй нээгдэв. Нэг ч харуул манааны хүн үзэгдсэнгүй. Аянчдыг оронгуут хаалга хаагдав. Дахиад гучаад алхмын дараа баруун хана төгслөө. Ингээд хадгалагчид Ойн Шилтгээнд ороод ирэв. Галадхэний оршин суугчид харагдсангүй, тэгсэн мөртөө тэдний дуу энд тэндгүй сонсогдоно. Уулан дээр яг л хаврын бороо шиг уянгалаг, хөгжилтэй дуу аяархан дуурсана.

Хадгалагчид нэлээд удаан өгсөв. Эцэст нь ногоон өнгийн дэнлүүгээр гэрэлтүүлсэн өндөр усан оргилуурт хүрлээ. Оргилуурын цаана, уулын орой дээр хамба хилэн мэт зөөлөн

мөнгөлөг холтостой, торго шиг зөөлөн сэрчигнэсэн алтлаг навчистай онцгой хүчирхэг аварга нарс ургажээ. Мод өөд цагаан шат тавьсан ба дээд үзүүр нь алтлаг бүрэнхийд уусах мэт үзэгдэхгүй болсон байна. Цагаан шатны доод гишгүүр дээр зэвсэгтэй гурван эльф сууж байна. Хадгалагчдыг үзээд харуулууд босч ирэв.

- Лориэний эзэд манай зочдыг дагуулж ирэхийг надад даалгасан юм – гэж Хэлдар хэлэв.

Эльфүүдийн нэг нь бүрээ үлээхэд дээрээс гурван удаа хариу үлээв.

- Явцгаая, би та нарт дээш замчилъя – Хэлдар хэлэв. Дээрээс эльф Леголаса болон намхан Фродо хоёрыг эхлээд оруулахыг хүсчээ. Бусад зочид дараа нь орно. Эздийн өргөө их өндөр учир замдаа ядарвал амарч болно гэж бас хэлж.

Фродо олон давхраар өгссөөр эцэст нь тал тал тийшээ салаалсан олон нээлхийн дунд асар том цагаан дэлонь үзэв. Фродо Хэлдарын араас тэр дэлонь дээр гартал том модон байшин байв. Хэлдар хоёр самбартай хаалгыг нээж, Фродог ор гэж дохив.

Фродогийн өмнө зөөлөн мөнгөлөг гэрэлтүүлэгтэй танхим байна. Шалнаасаа эхлээд таазаа хүртэл өөр өөр эрдэнийн чулуугаар доторлосон, зууван хэлбэртэй тэр танхим дотроо мөнх үргэлжлэх ид шидийн амьдралыг агуулсан эрдэнийн чулуу мэт санагдав. Танхимын төвд байгаа алтан ширээнд Селербэрн, Галадриэль хоёр сууж, олон шадар эльфүүд нь хүрээлжээ.

Хоббитыг хараад эзэд босч ирлээ. Эльфүүд зочноо ингэж хүндэтгэдэг заншилтай бөгөөд хамгийн агуу эзэд ч энэ ёсоо эвддэггүй билээ. Фродо тэр хоёрын агуу гоо сайхныг биширсэндээ арай л хашгирчихсангүй. Лориэны эзэд өндөр. Селербэрн Галадриэлиэс арай өндөр ажээ. Нүд гялбам цагаан, өргөн манти тэдний цэл залуугаараа гоолиг биеийг хааж үл чадна. Урт үс нь мөрөн дээрээ намиран буужээ.

Хааны үс мөнгөлөг, хатан хааных алтлаг өнгөтэй байв. Хааны насыг нүүрээр нь тодорхойлох аргагүй боловч тэнгис мэт гүн, үүрийн цолмон мэт хурц нүд нь хязгааргүй гүн ой ухаан, эртний их мэргэдийн туршлагатайг илтгэж байв.

Хэлдар хоббитыг хөтөлж эздийн дэргэд очиход Галадриэль нүд рүү нь зэрвэсхэн харж, Селербэрн нийтийн хэлээр өгүүлэв:

- Тавгай морилно уу, Хоббитаны Фродо! Бидний хажууд суухыг урья, тэгээд жаахан амар. Бусад нөхөд чинь орж ирсний дараа ярилцъя.

Орж ирсэн хүн бүртэй Селербэрн нэрийг нь хэлэн төрөлх хэлээр нь мэндэлж байв.

- Сайн байна уу, Трандуилын хүү бөгөөд элч! Манай умардын садан төрлүүд маань Ариун хязгаарт ирэхэд улам бэрх болж байгаа нь харамсалтай.

- Ороорой , Араторны хүү Арагорн! Чи манайд гучин найман жил байж, тэнүүлчийн хүнд бэрх амьдралыг туулсан. Би үүнийг чиний нүүрнээс харж байна. Гэвч тэмцэл удахгүй дуусна гэдгийг чи мэдэж байгаа. Харин одоо ажлаа түр март, Лориэнд чи тайван амарч болно.

- Сайн уу, Глоины хүү Гимли! Агуу эзэн Дариныг нас барснаас хойш Лориэний хил гномуудад хаагдсан. Чиний төлөө бид хуулиа зөрчлөө. Өнөөдрийн энэ уулзалт бидний эртний найрамдлыг сэргээж, Дундад газар дээгүүр нөмөрч байгаа хар үүлийг сарниахад туслах болтугай!

Гном эздэд гүнээ мэхийн ёслол.

Хадгалагчид танхимд цугларсны дараа Селербэрн тэднийг асуусан маягтай тойруулан харав.

- Элчийн хэлснээр бол Элрондын болсон Зөвлөл есөн хамгаалагчийг томилсон. Тэгэхлээр дараа нь ямар нэг өөрчлөлт гарчээ?

- Үгүй ээ, Зөвлөл шийдвэрээ өөрчлөөгүй – Галадриэли хэлэв. Түүний дуу хоолой тод, яруу боловч гэнэт намсав. Хадгалагчид дуугарсангүй. – Миний мэдэж буйгаар – гэж хатан хаан үгээ үргэлжлүүлж - Хадгалагчидтай хамт Саарал Гэндальф явсан. Би түүнтэй дахин уулзахыг их хүсч байгаа боловч шидтэн Лориэний хилээр орж ирсэнгүй, би түүнийг миний эзэмшлийн оронд байхад нь л хаашаа явахыг нь тандаж чадна, харийн газарт шидтэнийг тандах хүч хамгийн соргог нүдэнд ч байхгүй...

- Саарал Гэндальфыг харанхуй залгисан – гэж Арагорн хүндээр санаа алдан өгүүлээд – Тэр Мориугоос гарч ирж чадаагүй.

- Энэ бол үнэхээр аймшигтай мэдээ - гэж Селербэрн танхим дахь нам гүмийг эвдэн хэлээд Хэлдар руу харж: - Яагаад энэ тухай надад эртхэн мэдээлээгүй вэ? – гэж эльф хэлээр асуув.

- Хэлдар бидний уй гашууг мэдэхгүй – гэж Леголас нийтийн хэлээр өгүүлээд, эхэндээ бид Мориугоос яаж гарч ирснээ ярьж чадахааргүй ядарч туйлдсан байсан, дараа нь Лориэны анагаагч ид шид бидний зовлон гунигийг мартуулж, бид энэ тухай дурсахыг хүсэхгүй байсан.

- Мартуулсан, гэхдээ эдгээгүй, бидний гарз нөхөгдөшгүй, сэтгэлийн зовлон хэзээ ч арилдаггүй, Гэндальф биднийг Мориугоос гаргаж чадсан, биднийг аврахын төлөө ганцаараа тулалдаад амь үрэгдсэн!

- Хэрэв тэр та нарыг Мориугоос гаргаж чадсан юм бол яагаад өөрөө та нартай гарч ирээгүй юм бэ? – гэж Селербэрн ихэд гайхав.

- Үхчихсэн учраас – гэж Арагорн дуугараад – Би бүгдийг дэс дараатай ярьж өгье – гээд Арагорн Карадрас болсон цасан шуурга, хэрээнүүд, чонодолоохууд, Мориид ухарсан, Гүний отолт, түүх бичлэгийн өргөө, Балины булц, орхуудын довтолгоо, гүүрэн дээрх тулалдааны тухай бүгдийг яриад: - ... тэр бол Барлог – Харанхуйгаар халхавчилсан хүрэн гал байсан.

- Хүрэн уулын доорх гүний дайсан - гэж Леголас айдас нь сэргэх шахан шивнэв.

- Гномуудын сэрээсэн Гүний аймшиг буюу Дарины агуу хорт дайсан – гэж Гимли айдсаа нуулгүй хэлэв.

- Карадрасын гүнд аймшигт Хүрэн дайсан нуугдаж байгааг бид эртнээс мэдэж байсан гэж

Селербэрн хэлээд – Тэгэхлээр гномууд түүнийг дахиад хилэгнүүлсэн байх нь ээ? – гээд Гимли рүү харж: - Чамайг Лориэнд оруулсандаа би харамсч байна... чамайг болоод чамтай хамт яваа бүгдийг. Гэндальфыг солиот гэвэл зохино – ер нь Мории руу зөвхөн солиотой амьтан л орно! – гэхдээ тэр Мэргэн байсан... тэр солиорсон эсэхийг шүүх миний хэрэг биш.

- Саарал Гэндальф – хэзээ ч солиотой юм хийж байгаагүй – хэмээн Галадриэль ярианд оролцож – тэрнийг дагаж Мории руу орсон бүгд түүний төлөвлөгөөг бүрэн мэдэхгүй байсан. Ямар ч гэсэн Гэндальфын үйлдлийн төлөө зөвхөн Гэндальфыг л буруутгаж болно! Харин гномууд...

Хэрэв Лориэний ард түмэн Ариун хязгаараа орхиж, олон жилийн дараа бидний хэн нэг нь, жишээ нь Селербэрн Мэргэн хаан, дахиад Лориэнд ирэх байсан уу, тэр ийм боломжийг алдах байсан уу? Галадриэль түр бодолхийлснээ эртний түүх бичгийг сэргээн санах адил:

- Келед-Зарамын ус ёроолгүй, Кибель-Налын булаг мөс шиг хүйтэн. Гэвч Гүний аймшиг сэрээгүй байхад алдарт Казад-Думын гайхамшигт өргөөнүүд галтай ч, гэрэлтэй ч байсан... - гээд хатан хааны уянгалаг яриа тасарснаа түүний уруул дээр инээмсэглэл тодров. Уурлаж, хөмсөг зангидсан Гимли дайсагнаж байсан хүмүүсийнхээ нүднээс гэнэт нөхөрсөг өрөвдөл, чин сэтгэлийн хайр хүндэтгэлийг олж харлаа. Тэр эхлээд балмагдсан байртай, дараа нь баярласан царайтай инээмсэглэж, босоод гүнээ мэхийн:

- Гэвч Лориэний Алтан ой Мориин гантиг өргөөнөөс сайхан, Морийн хаант улсын нүд гялбуулсан эрдэнэс Лориэний хатан хааны гоо үзэсгэлэнгийн өмнө бүдгэрнэ! – гэлээ.

Эльфүүд болон хадгалагчид удаан дуугүй суув. Эцэст нь Селербэрн дахин ярьж эхлэв:

- Ширүүн үг хэлсэнд уучлаарай! Харамсал гуниг, түгшүүрээс болоод тэгж хэлчихлээ. Бид та нарт бүгдэд чинь туслахыг хүсч байна, ялангуяа тийм хүнд дарамт өөртөө үүрсэн энэ хүнд туслахыг хүсч байна.

- Та ямар зорилгоор аянд гарсныг бид мэдэж байсан –хэмээн Галадриэль Фродо руу харан хэлээд – Энэ аялал юугаар төгсөхийг би мэдэхгүй ч гэсэн Гэндальф та нарыг Лориэн руу дэмий дагуулж ирээгүй гэдэгт итгэж байна. Яагаад гэвэл Ариун хязгаарын ард түмэн анхдагч эринээс эхлэн дорнодтой хил залгаа амьдарч ирсэн учраас хар хорын үйлтнүүдийг дундад газрын бусад ард түмнээс илүү мэддэг юм.

Бид өрнийн анхны хамгаалалт унахаас ч өмнө уулс давж ирсэн, тэр цагаас хойш ялна гэсэн найдваргүй боловч аргаш ухралгүй хар хорын үйлтнүүдийг тогтоон барьж байна. Энэ эриний эхээр би анхны Дундад газрын гэгээн хүчнүүдийн зөвлөлийг зарлан хуралдуулсан, дараа нь мэргэдийн зөвлөл гэж нэрлэдэг болсон. Хэрэв анхны зөвлөл миний санал болгосноор Гэндальфыг Зөвлөлийн дээд мэргэнээр сонгосон бол амьдрал өөрөөр явах байсан байж магадгүй. Энүүхэндээ гэхэд Дундад газар өнөөдөр хамаг юмаа харахан алдчихаагүй байна. Олон зүйл та нарын аяллаас шалтгаална, тийм ч учраас би та нарт зарим зүйлээр тусалж чадах байх гэж бодож байна, яагаад гэвэл надад зөвхөн өнгөрсөн үе төдийгүй өнөө үед болж байгаа зүйлс, ирээдүйд болох зарим зүйлс ч нээлттэй байна. Одоохондоо би та нарт юу хэлэх вэ гэвэл: та нарын аялал бол хутганы ирэн дээгүүрх аялал. Нэг л удаа алдаж гишгэвэл та нар

төдийгүй Дундад газар сөнөнө. Та биднийг зөвхөн бие биедээ үнэнч зүтгэх л аварна.

Дараа нь хатан хаан хадгалагчдыг нэг хүн мэт нэгтгэх гэсэн мэт аажуухан тойруулан харахад хадгалагчид хөдөлж ч чадахгүй байгаага мэдрэв. Хатан хаан доош харснаа үгээ үргэлжлүүлж:

- Харин одоо та нарыг амралт хүлээж байна – гэлээ.

Хадгалагчид санаа амарсан, бас ядарсан шинжтэй санаа алдав. Эхлээд хатан хааны толгой мансууруулж, зүрх булгилуулсан харцнаас Леголас, Арагорн хоёроос бусад нь өөртөө нэг л түгшүүртэй, итгэлгүй болсон /Сэмийн царай бүр час улайсан байв/ бол одоо гэнэт тайвширч, дэндүү их ядарснаа мэдрэв.

- Сайхан нойрсоорой, та нар минь уй гашуу, элдвийн хүнд бэрх адал явдалд ядарч туйлдсан, гэвч бид та нартаа Дайсны тоолшгүй зарц нартай тэмцэх хүчээ сэлбэхэд чинь тусална – гэж Селерберн хэлэв.

Энэ шөнө хадгалагчид модонд авирч хоноогүй нь дөрвөн хоббитод бөөн баяр болов. Эльфүүд усан оргилуурын дэргэд майхан босгож, тохитой ор дэр бэлтгэж, сайхан амрахыг ерөөгөөд гарлаа. Эльфүүдийн дуу намдсаны дараа аянчид өчигдрийн хоносон газрын тухай ярьж, агуу Эмросын булшийг дурсан ярьж, Лориэний эздийн тухай сэтгэгдлээ ярьсан боловч Морийд болсон адал явдлуудын талаар ярих тэнхээ байсангүй.

- Чи хатан хааныг ярихад яагаад улайсан бэ? Эльф найз нар маань чамайг ямар нэг заваан юм бодож магадгүй гэх байсан шүү дээ. Чиний дандаа заваан юм бодож байдаг толгойд миний хөнжлийг гутамшигтайгаар хулгайлахаас өөр аюултай муухай юм байхгүй гэдэгт итгэж байна – гэж хэрэгт дуртай Пин цаашлуулав.

- Хөнжил мэтийн юм түүний харцнаас намайг нууна гэж үү? Тэр миний зүрх рүү өнгийгөөд харчихсан! Миний нүд рүү харж байгаад хэрэв би чамайг Хоббитан руу явуулах санал тавибал чи яах вэ? – гэж асуусан. Бас амьдрах байшинтай цэцэрлэг амласан шүү!

- Өө тэгдэг юм биз дээ! – гэж Пин дуу алдаад – тэр бас надад ... за яриад байх ч юу байх вэ дээ – гээд тэр ичсэн бололтой дуугүй болов.

Хадгалагчид бие бие рүүгээ хараад, хатан хаан үнэнч зүтгэл ба хамгийн гэгээн мөрөөдлийнхөө хооронд хатуу ширүүн сонголт хийхийг санал болгосныг ойлгов. Энэ бол бүх нийтийн дайсны эсрэг үхлийн аюулт тэмцлийг бусдын мөрөн дээр хая, эсвэл мөрөөдлөө биелүүл гэсэн үг байжээ.

- Тийм ээ, яриад байх юм байхгүй - гэж Гимли хэлээд дуугүй боллоо.

- Миний бодлоор бол ярих ёстой - гэж Боромир эсэргүүцээд - Магадгүй хатан хаан биднийг мэдэхгүй ч гэсэн сайн сайхан санаагаар сорих гэсэн байж болно... ямар ч гэсэн тэр биднийг яах гэж ингэж уяраав? Амлалтаа биелүүлж чадна гэж бидэнд ийм уран итгүүлэв? ... мэдээж би түүний яриаг сонсохоо больсон. Хэлсэн үгэндээ эзэн байх бол гондорчуудын хууль...

Хатан хаан түүнд юу амласныг хадгалагчид мэдэж амжсангүй, учир нь Боромир Фродод хандаж:

- Хатан хаан чамайг юугаар татав?

Фродо түүнд хариу хэлэхийг хүссэнгүй.

- Энэ талаар ярих хэрэггүй гэж би бодож байна – гэж Гимли хэлэв.

- Сэрэмжтэй л байгаарай! Хатан хаан юу бодсон нь тодорхой биш байна гэж тэр Фродод анхаарууллаа.

- Тодорхой шүү дээ! Харин чи юу ярьж байгаагаа мэдэхгүй байна. Энэ дэлхий дээр Хар хоронд гишгэх газар байхгүй. Хар хорон үйл хар хорон үйлтнүүдийн санаанд ч үхэж байна... амьдралынх нь цорын ганц үндэс нь хар хорон үйл болсон тэд ч үхэж байна. Тийм учраас би Уудам хөндийгөөс гарснаас хойш өнөөдөр анх удаа тайван унтлаа. Бидний зовлон бэрхшээл, уй гуниг түр зуур ч гэсэн ор мөргүй боллоо гэж би найдаж байна. Бид сайхан амрах хэрэгтэй – гэж Арагорн хэлээд тэр дороо нам унтав.

Удалгүй бусад хадгалагчид ч унтлаа. Тэдний нойрыг зүүд ч үймүүлсэнгүй, ер бусын удаан унтав. Тэд унтаж ханаад майхнаасаа гарч ирэхэд тэнгэрт мөнгөлөг наран гийж, өндөрт цацрах усан оргилуурын нуман дээгүүр тод солонго татаж байв.

Галадхэний дээгүүр цэлмэг өдрүүд ар араасаа туяарч, хэдэн өдөр өнгөрснийг ч хадгалагчид тоо алджээ. Заримдаа дорно зүгээс үүл нүүн ирж, бороо асгараад тэр дороо цэлмэж, үүлэн сүрэг баруун зүг нүүн одож, өдрөөс өдөрт улам дулаарсаар тунгалаг агаарт хаврын амьсгал орж байсан ч зөөлөн ойн гүнд өвлийн амьсгал хэвээрээ байлаа. Хадгалагчид Галадхэний хязгаараар зугаалж, цадталаа идэж, ханатлаа унтахаас өөр юм хийсэнгүй. Гэвч тэдэнд энэ амьдрал уйтгартай санагдсангүй нь тэд урт аяны бэрх замд эцэж туйлдсаных биз ээ.

Эзэд тэднээс өөр зочид урьсангүй, шилтгээнд амьдардаг бусад эльфүүд нийтийн хэлийг мэддэггүй. Хэлдар тэдэнд аян замын ерөөл тавиад умард хил рүүгээ буцлаа. Леголас төрөл садангуудаараа хэсээд, майхандаа ч бараг хонохоо больж, зөвхөн үдийн хоолоо идэх гэж л ирнэ.

Гендальфын тухай ярихаас зайлсхийж байсан шинэ шарх мэт уй гуниг аажмаар баярлаж талархсан гэгээн гуниг болон хувирч, одоо тэд нар түүнийг байн байн дурсан ярьдаг болов. Эльфүүдийн уянгалаг аялгуут дуунд алга болсон нөхрийнх нь нэр байн байн гарч байхыг бодвол лориэнчүүд шидтэний дурсгалыг хүндэтгэн ёсолж байгаа ажээ. “А митрандер э сервэн” хэмээн Галадхэний оршин суугчид гунигтайгаар дуулж байсан бөгөөд Леголасын орчуулснаар эльфүүд Гендальфыг “Саарал тэнүүлч” гэж эерүүлэн нэрлэж байгаа юм гэнэ. Гэвч Леголас дууны үгийг орчуулахаас татгалзаж, миний яруу найргийн авьяас хүрэхгүй, тэгээд ч эдгээр дууг сонсохоор дуулах нь бүү хэл уйлмаар байна гэнэ.

Хамгийн түрүүнд уй гашуугаа дуунд шингээсэн хүн нь хачирхалтай ч гэсэн Фродо байлаа. Тэр өөрөө бараг дуулдаггүй, Уудам хөндийд байхдаа ч эльфүүдийн дууг сонсохоос бус өчнөөн

олон дуу мэддэг ч гэсэн өөрөө огт дуулж байгаагүй билээ. Харин одоо лориэнчүүдийн дууг сонссоор өөрөө Гэндальфын тухай дуу зохиожээ. Гэвч тэр зохиосон дуугаа Сэмд дуулж өгөхөд нь хатсан навч салхинд хийсэн тарж байгаа юм шиг эв хавгүй бадгууд байлаа.

Үдшийн бүрий болоход

Хөлийн чимээ нь дуулддаг сан,

Үүрийн гэгээ тусахад

Үг дуугүй босоод алхдаг сан.

Харанхуй агуй, уудам талаар

Хар шуурга, замын тоосонд

Халуун хүйтнийг үл ажран

Хаа сайгүй яваад л байдаг сан.

Бүх овог, үндэстний хэлийг

Бүгдийг нь тэр мэддэг байлаа.

Галаар тургилсан лууны хэлийг ч

Гаргуун сайн ойлгодог байлаа.

Гарцаагүй үхлийн илд барьсан ч

Гар нь хүртэл анагаагч байлаа.

Буурал тэргүүнт эрхэм шидтэн

Буцаж ирэхгүй аянд мордлоо.

Ядарч тулдсан өвгөн дайчин

Ялан дийлэгч эртний баатар

Гав ганцаараа гүүрэн дээр

Галзуу дайсантай тулсан юм...

- Хөө-өх, мөдхөн Бильбогоос ч мундаг шүлэгч болох юм байна – гэж Сэм магтав.

- Буруу хойшоо шүлэгч бол доо, гэвч чадлынхаа хэрээр л хийлээ.

- Гэхдээ эзэн минь, элдэв гайхамшигтай галын наадам хийдэг байсан талаар нь ганц бадаг оруулбал ямар вэ? Жишээ нь нэг иймэрхүү юм:

Гайхам цэцэрлэг мэт пуужин харваж

Галаар тэр тэнгэрийг цэцэглүүлдэг сэн,

Аянга цахилгаан цахилуулж

Аварга лууны дуу гаргадаг сан.

- Үүнийгээ чи өөрөө л бич. Эсвэл Бильбо хэзээ нэг цагт бичнэ биз. Харин би одоо Гэндальфын тухай дахиж ярих тэнхэл алга. Түүний тухай Бильбод яаж ярихаа ч мэдэхгүй байна...

Фродо, Сэма хоёрын сэтгэл нэг л түгшүүртэй болов. Тэр хоёр ойгоор зугаалж явахад аварга нарснуудын навчис тэдэнд Лориэн оронтой салах ёс хийх цаг боллоо гэж шивнэх мэт санагдлаа.

- Чи эльфүүдийн тухай юу гэж бодож байна Сэм? Урьд нь би чамаас ингэж асууж байсан л даа. Гэвч бид хоёр тэр цагаас хойш эльфүүдийг илүү их мэддэг болсон – гэж Фродо асуув.

- Энэ эльфүүд чинь бүгдээрээ хоорондоо садан төрөл мөртөө бас өөр хоорондоо их ялгаатай юм байна. Эльф гэдэг нэг л үг, тэдний дуу хоолой хэнтэй ч андуурамгүй содон.... харин хараад байвал хоорондоо огт адилгүй юм байна. Наанадаж эндхийн эльфүүдийг манай Леголастай харьцуулаад үзвэл огт өөр. Эндхийнхэн яг л бид Хоббитандаа хайртай шиг энэ ариун газартаа хайртай. Тэд энэ газар нутгаа өөрсдийнхөө хүссэнээр өөрчилсөн юм уу, газар нутаг нь тэднийг өөртэйгээ адилхан болгосон юм уу би хэлж мэдэхгүй, гэхдээ л эднийхэн газар нутагтайгаа адилхан юм. Тэд ямар ч өөрчлөлт хийхийг хүсэхгүй байна, өөрчилье гэсэн ч яагаад ч өөрчлөх боломжгүй нутаг. Эдэнд маргааш гэж байхгүй, өглөө босоход дахиад өнөөдөр л болно... би юун тухай ярьж байгааг та ойлгож байгаа биз дээ. Бас эдний шидтэнг би огт харсангүй...

- Тэрнийг чинь ч харин алхам тутамдаа мэдэрч байна шүү! гэж Фродо Сэмийн үгийг таслав.

- Мэдрэх нь ч мэдэрч л байна л даа, харин үзэгдэж харагдахгүй л юм байна. – гэж Сэм эзнээсээ зөрөв: - Жишээ нь Гэндальф байна, тэр бол ёстой жинхэнэ шидтэн байсан, яаж гал гаргаж байсныг нь санаж байгаа биз дээ? Тэнгэр тэр чигээрээ шатаж байсан, сохор амьтан ч үзнэ... Эзэд биднийг дахиж дуудахгүй нь харамсалтай байна. Эдний хатан хаан жинэхэнэ ид шидийг үзүүлнэ дээ гэж би бодоод байна... Тэрийг нь харах юмсан! Нэгэнт хөөрхий Гэндальф өнгөрснөөс хойш та ч гэсэн дуртайяа үзэх болно доо.

- Үгүй ээ, энд тэртэй тэргүй сайхан байна. Харин Гэндальф надад ямар ч ид шидгүй хэрэгтэй байна. Би түүнд шидтэн учраас хайртай байгаагүй.

- Тэр ч тийм. Би тэдэнд муу юм саналаа гэж та бүү бодоорой. Би зүгээр л эртний үлгэрт

гардаг шиг жинхэнэ гайхамшигийг үзмээр байна. Энэ хязгаар Уудам хөндийгөөс ч сайхан юм. Энд байхад гэртээ байгаа юм шиг л байна, баяр наадамд оролцох гээд зочилж ирсэн юм шиг... би юун тухай ярьж байгааг та ойлгож байгаа биз дээ. Эндээс явмааргүй л байна. Гэвч бидний ажлыг бидний өмнөөс хэн ч хийж өгөхгүй болохоор явахаас яах билээ. Суудал дээрээ суугаад ажил бүтэхгүй гэж аав маань ярьдаг юм. Бидний аялалд эндхийн эльфүүд ид шидтэй байлаа ч нэг их тус хүргэхгүй гэж надад санагдаад байна. Эд нар жинхэнэ шидтэний дэргэд юу ч биш! Бид Гэндальфгүйгээр замдаа гараад их юм үзнэ дээ!

- Тэгэх л байх даа. Ямар ч гэсэн хатан хаан бидэнд үдэлтийн хүлээн авалт хийх байх гэж би бодож байна.

Фродог ингэж хэлэнгүүт урьдаас нь өндөр гоолиг, үзэсгэлэнт хатан хаан гараад ирлээ.

Тэрбээр мань хоёр хоббитыг гараараа даллаад толгойн оройг зүүн талаас нь тойрон хашлагаар хашсан талбайд орж ирэв. Хоббитууд алхаагаа удаашруулан эргэн тойрноо харлаа. Эздийн өргөөний дэргэдэх усан оргилуураас эх авсан горхи энэ талбайн дундуур урсч байна. Горхины дагуу налуу шат тавьжээ. Гурвуулаа шатаар доош уруудахад толь мэт тунгалаг цөөрмийн дэргэд цагаан гантиг явган ширээн дээр мөнгөн аяга, мөнгөн домбо тавьжээ.

Хатан хаан бөхийж домбыг аваад уснаас хутган мөнгөн аяганд дүүргэв. Тэгээд ус руу үлээллээ:

- Энэ бол Лориэний хатан хааны толин цөөрөм. Би та нарыг эр зориг чинь хүрдэг юм бол ердийн үзэгдлийн цаана юу байдгийг харуулья гэж бодсон юм - гэлээ.

Хөхөвтөр манант үдшийн бүрийд Галадриалийн гоо биеэс хүйтэн ягаан туяа цацарч байх мэт догдолсон хоббитуудад санагдав.

- Яах гэж бид ердийн үзэгдлийн цаана юу байдгийг харах ёстой юм бэ? – гэж Фродо асуув.

- Миний хүссэнээр Шидэт толь минь та нарт хүссэн бүхнийг чинь харуулна. Гэхдээ Толинд бүрэн эрх чөлөө олгох нь үүнээс хавьгүй илүү сонирхолтой, бас ашигтай. Толь та хоёрт чухам юу харуулахыг би мэдэхгүй байна. Та нарын өнөөдрийн амьдралын замыг тодорхойлсон өнгөрсөн үеийг үзүүлэх юм уу, ирээдүйд та нарын хувь заяа ямар байхыг тодорхойлж байгаа өнөөгийн үйл явдлыг харуулах юм уу бүү мэд. Тэгээд ч та хоёр өнгөрсөн, одоо, ирээдүйн ямар үйл явдал өмнө чинь нээгдэж байгааг ойлгохгүй л байх аа даа...

Хатан хаан хэсэг дуугүй байснаа Фродогоос: - Тэгээд чи миний толинд харахыг хүсч байна уу үгүй юу? – гэж асуулаа.

Фродо түүний асуултад хариулсангүй.

- Чи хүсч байна уу? – гэж Хатан хаан Сэмээс асуув. Миний мэдэж байгаагаар бол үүнийг илбэ гэх байх. “Илбэ” гэдэг үг надад тийм ч ойлгомжгүй – тэгээд ч та нар Дайсны хэрэглэдэг арга мэхийг илбэ гэж нэрлэдэг шүү дээ. Чи эльфийн шидтэнийг үзэх юмсан гэж ярьсан, чинийхээр бол жинхэнэ ид шид гэж юу байдгийг миний шидэт толиноос л харах байх гэж би

бодож байна.

-Би оролдоод үзье гэж Сэм өөртөө итгэлгүйхэн хэлээд Фродо руу эргэн харж санаа алдаад: Уутан хясаагаа нэг харахсан. Биднийг гэр орондоо байхад айдас гэж Юу байсан юм бэ? Ид шидээр Норгордыг харуулна гэж үү? Би тэр идээр чинь танихгүй оддыг харах юм гэж үү?... эсвэл яагаад ч ойлгох боломжгүй юмыг харах уу?

- Гэлээ ч гэсэн оролдоод үз! Харин усанд гараа хүргэж болохгүй шүү - гэж Галадриэль хэлэв.

Сэм цөөрмийн эрэг дээрх шатан дээр гараад мөнгөн аяга руу болгоомжтой харлаа. Толь мэт тунгалаг усанд зөвхөн оддын тусгал л харагдана.

- Мэдээж шүү дээ, од л харагдаж байна....гэснээ гэнэт таг дуугүй болов. Тод одод гялалзсан харанхуй тэнгэрийн оронд гэнэт наран хөгжилтэйгээр мандаж, моддын навчис салхинд намуухан чичрэн байлаа. Гэвч хоббит юу үзсэнээ ухаарч ч амжсангүй, гэрэл бүүдгэрч, манан дунд ямар нэг чулуун хананы дэргэд хэвтэж байгаа Фродог харсан бөгөөд царай нь үхсэн мэт цайсан байлаа. Дараа нь үзэгдэл дахин хувилж, Сэм өөрийгөө харлаа. Тэр төгсгөлгүй урт хонгилуудаар тэнэж, тахирлаж махирласан шатаар өгсч, хэн нэгнийг эрж хайгаад байлаа. Чухам хэнийг вэ?.. сэрж унтахын хоорондох сэрүүн зүүд мэт дахин нар гийж, моддын навчис чичигнэн дэрвэж байвч салхинаас биш, сүхний цохилтын улмаас дэрвэж байгаа юм шиг санагдав. Сэм сандарч гүйцэв.

- Энэ чинь юу гээчийн ид шид вэ! – гэж тэр уурласан байртай хэлээд – Хэн энэ хараал идмэрт ингэхийг зөвшөөрсөн юм бэ? Энэ моднууд бол Норгордод их ашигтай, тээрмээс Голын хөндий хүртэл зам сүүдэрлэдэг юм. Гэтэл энэ хараал идсэн хар үйлтэн хяргаж байдаг! Одоо Хоббитанд яваад очдог ч болоосой, тэгвэл тэр новш миний моддыг гуйгаагүй байхад миний нүдний өмнө цавчихгүй л байсан даа! – хэмээн хилэгнэв.

Гэвч Сэм анхааралтай ажиглаад, хуучин тэрэм байсан газар нэг муухай гэгч нь тоосгон байшин баригдаж, түүний дэргэд утаа тортог болсон улаан тоосгон яндан тэнгэр баганадан босч байна. Утаа бөөгнөрөн өтгөрч, Толийг хар хөшгөөр харанхуйлан өтгөрөв.

- Норгордод ч онцгүй байгаа юм байна даа. Ноён Элронд Пинийг гэр рүү нь явуулахдаа юу хийж байгаагаа мэдэж байсан юм шиг байна,...Мөн ч муухай амьгад юм даа ! – гэж тэр босон харайгаад: Би ерөөсөө гэртээ харилаа. Тэд миний эдлэнг нурааж, аавыг минь хөөж гаргасан байна. Аав маань бага сага эд хогшлоо тэргэнцэрт ачаад Норгордоор явж байхыг нь харлаа.

- Чи ганцаараа харьж чадахгүй шүү дээ, чи гэртээ харихыг хичнээн их хүсч байсан ч Фродог орхиод явах эрхгүй гэж шийдсэн. Толь цаг нь хараахан болоогүй үйл явдлуудыг үзүүлэх явдал ч байдаг, хэрэв үзсэн хүн ирээдүйд болзошгүй муу явдлаас сэргийлэхийн тулд нэгэнт сонгосон замаасаа буцаж няцахгүй байвал тэр үйл явдал нь хэзээ ч тохиолдохгүй байх магадлал ч өндөр. Шидэт толь бол аюултай зөвлөгч шүү - гэж Галадриэль анхааруулав.

- Надад ямар ч зөвлөгөө хэрэггүй, ид шид ч хэрэггүй - гэж Сэм бувгнав. Тэгээд өвсөн дээр сууж таг дуугүй болов. Тэгснээ Бидний гэр рүүгээ явах зам Мордороор дайрч өнгөрөх нь илт байна. Хэрэв бид Хоббитандаа хүрч чадах юм бол байдал яг толинд харагдсан шигээ байх нь.

Тэгвэл тэр муу хар үйлтнүүд өөрсдийнхөө тархи руу шаах болно доо! –хэмээн занав.

- Чи толинд харахгүй юм уу? Чи энд хаа сайгүй ид шидийг мэдэрч байна гэж хэлсэн шүү дээ... Эльфийн ид шид чамайг бишрүүлэхгүй байгаа юм уу?

- Би өөрөө ч мэдэхгүй байна – Фродо хэсэг зуур байзнаснаа: - Би энэ толинд харах хэрэгтэй гэж чи бодож байна уу?

- Би чамд юу ч зөвлөхгүй, өөрөө л шийд. Тэгээд ч толинд харагдсан зүйлийг зөвлөгөө гэж бодож хэрэггүй, учир нь бидний амьдралыг өөрчилж болох ирээдүйн үйл явдлыг тохиолдлоор урьдчилж мэдээд сонгосон замаасаа буцаж, хувь заяанаасаа урвах явдал гардаг юм. Тохиолдлын мэдлэг заримдаа бидний тэмцэлд маш их тус болдог ч гэсэн маш аюултай... Миний бодлоор бол, толинд харсан зүйлээ зөв ойлгоход хангалттай хүрэлцэх мэргэн ухаантай, эр зоригтой, хүссэнээрээ л бол –гээд Галадриэль дуугүй болов.

- Би харахыг хүсч байна – гэж Фродо хурдан хэлээд тавцан дээр гарч Толь руу харав. Усны гилгэр мандал тэр дороо гэрэлтэж мань хоббитын нүдэнд жаргаж буй нарны туяанд гийгүүлэгдсэн тэгш өндөрлөг үзэгдэв. Тэртээ алсад уулс хөндөлсөн, тэр уулсаас Фродо руу нэгэн зам дөхөжирснээ зүүн тийш огцом эргэж, тэнгэрийн хаяа руу алдарч байна. Замаар дөнгөж үзэгдэх төдий цэг мөлхөж яваа харагдана. Сайтар харвал жижигхэн хүн... Мань хоббитын зүрх баярлан догдлов. Тэр бол цагаан цувгай, гартаа очир барьсан Гэндальф яах аргагүй мөн гэдэгт Фродо итгэлтэй байв. Харин түүний нүүрийг харсангүй, тэр замаар зүүн тийш эргэж, тэнгэрийн хаяа руу одлоо. Фродо дараа нь тэр цагаан дүрсийг эргэн санахдаа Гэндальфыг харсан юм уу, Саруманыг харсан юм уу гэдгээ мэдэхгүй байлаа. Тэгш өндөрлөг алга болж, өөр үзэгдэл гарч ирэв.

Нэгэн жижиг өрөө байх бөгөөд баахан бичигтэй цаас овоолсон дөрвөлжин ширээ байна. Цонх руу бороо шүршиж байна, цонхноос хаалга хүртэл Бильбо нааш цааш холхиж байна, хөгшин хоббит ямар нэг зүйлд маш их санаа зовж байгаа бололтой холхиж байснаа гэнэт нам зогслоо, гэвч толины мандал жирэлзэж, өрөө алга боллоо.

Шидэт толь дахин тодроход өөр үзэгдлүүд ээлжилсэн нь түүний нүдний өмнүүр агуу их Түүхийн үе гялалзан өнгөрлөө, тэр түүхэнд хувь заяа өөрийг нь хөтлөн оруулсныг гэнэт тодхон ухамсарлав.

Түүний өмнө тэнгисийн шуурга гарч ирлээ. Тэр урьд нь тэнгисийг огт үзээгүй боловч энэ бол яг тэнгисийн шуурга мөн гэж шууд мэдэв: - Оволзон сүмбэрлэх буурал давалгаа, нар хаасан хүнд хар үүлс, гэтэл нар үүлэн цоорхойгоор гялсхийн цухуйхдаа дорно зүг рүү хөвж яваа хөлөг онгоцыг гэрэлтүүлэв. Дараа нь олон хүнтэй том хотын дундуур урсч байгаа хүчирхэг мөрөн, тэгээд цагаан чулуугаар барьсан долоон өндөр цамхаг бүхий уулын бардам цайз. Дараа нь өглөөн нар туяарч, нам тайван тэнгисийг гэрэлтүүлэв. Хөхөвтөр усан мандлыг цагаан модон иштэй нарийхан далбаа бүхий хар далбаат онгоц зүсэн явж байна. Хөлөг онгоц эрэг рүү аажуухан ойртож, тэр дорхноо утаан хөшигний цаагуур далд оров. Нар жаргаж, харанхуй бүрэнхийд төгсгөлгүй их дайны цуст тулалдаанууд хэсэг бусгаар тодроод хав харанхуй болж, Фродо юу ч ялгаж харахаа болив. Харанхуй бага зэрэг гэгээрэхэд эргээс нэгэн мөнгөлөг хөлөг гарч ирээд төдөлгүй тэнгисийн уудамд үзэгдэхгүй болов. Фродо тавцангаас

буухаар бэлтгэлээ.

Гэвч толины мандал дахин харанхуйлж, ёроолгүй хоосон руу орсон хар нүх мэт харанхуйлав. Тэгснээ нэгэн НҮД харанхуйгаас толины мандалд хөвөн гарч ирээд Фродо руу аажим ойртлоо. Хүрэн улаан галан сормуусаар хүрээлэгдсэн, үхсэн мэт шар туяа татуулсан тэр нүд яах аргагүй амьд нь илт бөгөөд цооног мэт хүүхэн хараа нь нэг өргөсч нэг нарийсан судас нь цохилж байлаа. Фродо хөдөлж ч чадахгүй, дуугарч ч чадахгүй тэр нүд рүү харсаар байв.

Цусан судлуудаар хэрчигдсэн шил шиг гөлгөр нүд толин аяганд эргэлдэж, айдаст хүлэгдсэн Фродо тэр нүд ертөнцийг нэгжин, бөгж хадгалагчийг олж харахыг хичээж буйг ойлгосон боловч одоохондоо түүнд тэр нүдийг эсэргүүцэх зориг байна, одоохондоо өөрөө тэрнээс зугтаахгүй, нүд түүнийг олж харах чадваргүй гэж мэдэж байлаа. Ер бусын хүнд болсон бөгж нарийхан гинжийг чангаан, хоббитын хүзүү доошлов. Толины ус оргилон буцаллаа.

- Болгоомжтой найз минь. Усанд бүү хүрээрэй – гэж Галадриэль зөөлөн хэлэхэд Фродо харлан буцлах уснаас овсхийн хөндийрөхөд нүд бүдгэрсээр алга болж, толинд үдшийн одод тусав. Фродо тавцангаас яаран буугаад айж чичирсэн хэвээрээ хатан хаан руу харав.

- Хамгийн сүүлд харсан зүйлийг чинь би мэднэ. Айх хэрэггүй. Уянгат дуу хуур, эльфийн дайчдын сумны аль нь ч Лориэнийг Хар эзнээс халхлахгүй гэдгийг санаж яв. Учир нь тэр эльфүүдийн тухай бодох бүрт тэрний далд санаа надад ил болдог, тиймээс би тэрний хар санаанаас хамгаалж чадна, харин тэр миний санаанд нэвтэрч хэзээ ч чадахгүй.

Хатан хаан дорно зүг рүү харж, зүүн гараараа ямар нэг юм зайлуулах шиг болоод, баруун гараа тэнгэр өөд аажуухан өргөв. Эльфүүдийн хайртай үдшийн гялаан маш хурцаар гэрэлтэж байсан учир Хатан хааны биеэс газарт бүдэгхэн сүүдэр унаж байлаа. Ойн цоорхойд шөнийн харанхуй нөмөрсөн боловч, гэнэт цахилгаан цахих мэт болж, Лориэний хатан хааны зүүн гарт зуувин хэлбэртэй, солонгорсон сувдан шигтгээ бүхий алтан бөгж гялсхийв.

- Тийм ээ, гурван бөгжний нэг нь Лориэнд хадгалагдаж байгаа - гэж Галадриэль нэг ч үг хэлээгүй мөртөө батлаад – Нэнья бөгжийг надад итгэн хадгалуулсан юм. Дайсан энэ тухай одоохондоо мэдэхгүй. Тиймээс чиний ялалт юм уу, ялагдлаас Ариун хязгаарын хувь заяа хамаарна. Хэрэв чи замдаа үрэгдвэл, Дундад газрын ид шид хар муу үйлтнүүдийн өмнө сөхөрнө, хэрэв чи үүргээ биелүүлж чадвал ертөнц бүхнийг захирагч Цаг хугацаанд захирагдан, бид Ариун газраас явж, шинэ дээд захирагчид сайн дураар бууж өгөөд, үхэлт амьтад болно, түүнээс өнгөрсөн үеийн тухай дурсамж ч аварч чадахгүй.

Галадриэль дуугүй болж, Фродо ч дуугарсангүй. Дараа нь Хатан хааны нүд рүү харж байгаад асуув:

- Хэрэв чамд сонгох эрх өгөх юм бол чи ямар хувь заяаг сонгох байсан бэ?

- Харамсалтай нь надад сонгох эрх өгөөгүй – гэж Хатан хаан гунигтай хариулаад – Бид Лориэнийг үүрд дурсан санах болно. Тэнгисийн цаана гарлаа ч гэсэн, Ариун газартаа байлаа ч гэсэн, - бидний уй гуниг хэзээ ч зөөлрөхгүй. Гэхдээ Сауроныг ялахын тулд эльфүүд эх орноосоо татгалзахад бэлэн байна – иймээс бид хадгалагчдыг хүлээж авсан юм. Та нар

Лориэны хувь заяаг хариуцахгүй ... хэрэв би бүтэхгүй зүйлийг мөрөөддөг сөн бол Дайсны бөгж Их Андуин мөрөнд үүрд живж алга болоосой гэж хүсэх байсан.

- Чи мэргэн, аймшиггүй чин зоригтой, бас шударга – гэж хоббит хэлээд - Чи хүсвэл би Дайсны бөгжийг өгье? Дайсны их хар хүчийг би дийлэхгүй.

Хатан хаан гэнэт цангинатал инээв.

- Тэгэхээр, мэргэн, аймшиггүй чин зоригтой, бас шударга юм биз дээ ? – гэж инээсэн хэвээрээ асуугаад - Чамайг миний өмнө анх удаа зогсоход би чиний зүрх рүү харсан юм, чи үүний төлөө надаас хариугаа авч чадлаа. Чи гайхалтай мэргэн хараатай болж байна Хадгалагч аа! Нуугаад яахав, хэрэв Дайсны бөгж миний гарт орвол би яах вэ – гэж би олон удаа бодож байсан, гэтэл одоо би гартаа оруулж чадахаар боллоо! Хар муу үйл ямагт хар муу үйлийг төрүүлдэг, тэрнийг энэ ертөнцөд хэн авчирсан нь хамаагүй, - тэгэхээр би чамд итгэж хадгалуулсан бөгжийг гартаа оруулбал би агуу их сайн үйл бүтээх бус уу?

Тэгээд ч би бөгжийг хүч хэрэглэхгүйгээр авч байгаа болохоор би Хар хатан хаан болохгүй! Би гэнэтийн шуурга мэт хүчирхэг, шөнийн тэнгэрт хүржигнэх аянга мэт аймшигтай, гантай цагийн нар шиг хурц бөгөөд хайр найргүй, галын дөл шиг хайр хүндэтгэл хүлээсэн, шөнийн одод мэт хүйтэн болно. Хэхдээ ХАР болохгүй!

Тэрбээр зүүн гараа тэнгэрт өргөхөд, Нэнья бөгж гэнэт хурц гэрэл цацруулж, Фродо айсандаа арагш ухрав, учир нь Галадриэль яг саяны ярьсан шигээ нүд гялбам үзэсгэлэн гоо, ухаан алдтал аймаар сүрлэг догшин харагдав. Гэвч тэр дахин уянгатайяа инээгээд гараа буулгахад бөгжний гэрэл бүдэгрэв. Фродо буруу ойлгосноо мэдээд санаа амрав:

Түүний өмнө эльфүүдийн Хатан хаан зогсч байлаа. Өндөр гоолиг хэвээрээ ч эмзэгхэн, үзэсгэлэн төгс хэвээрээ ч сүрлэг догшин биш, гялалзсан жанчтай биш цагаан нөмрөгтэй, дуу хоолой нь гуниглангуй тайван байв.

- Би сорилтыг давсан, тиймээс би Тэнгисийн цаана гарч Галадриэль хэвээрээ үлдэнэ.

Хатан хаан удаан дуугүй сууснаа:

- Явцгаая. Маргааш та нар Лориэнийг орхино, сонголт нэгэнт хийгдсэн, цаг та нарыг хүлээхгүй. Одоо Хаан та нартай уулзахыг хүсч байна.

- Гэвч эхлээд миний Гэндальфаас асууж амжаагүй нэг асуултад хариулна уу. Асуух гэж бодож байсан ч эхэндээ зориг хүрээгүй, дараа нь тэр Морийн агуйд амь үрэгдсэн. Надад гол бөгжийг итгэж хадгалуулсан, бусад хадгалагчид нь хаана байна? Яагаад би тэдний нууц санааг мэдэхгүй байна?

- Чи харахыг ч хүсээгүй, мэдэхийг ч хүсээгүй. Хэзээ ч мэдэх гэж бүү оролд! Оролдвол чи зайлшгүй сүйрнэ. Гэндальф чамд бөгжний хүчин чадал хадгалагчийнхаа хүчин чадлаас хамаарна гэж чамд хэлээгүй гэж үү? Хэрэв чи жинхэнэ агуу хүчит мэргэн болоогүй мөртөө бөгжийг хэрэглэвэл эрт орой хэзээ нэгэн цагт Дайсан чамайг өөрийнхөө хүсэл зоригт

захируулна, чи өөрөө мэдэлгүй тэрний хүссэн бүхнийг биелүүлж эхэлнэ. Чи өөрийгөө Хадгалагч болохоос Эзэмшигч биш гэдгээ санаж яв: Чамд бөгжийг эзэмшүүлээгүй, хадгалуулсан юм. Чи бөгжийг гурван удаа хуруундаа зүүсэн... Өөрөө зүүе гэж бодоод зүүсэн гэж бодож байна уу? Гэхдээ л чи гайхалтай мэргэн ухаантай! Чи миний нууц санааг мэдэж байгаа, үүнийг мэддэг мэргэн тун ч цөөхөн! Чи агуу Дайсны нүдийг харсан, Нэнья бөгж миний хуруунд байгааг харсан... Чи миний бөгжийг ажиглаж амжсан уу? – гэж Хатан хаан Сэмээс асуув.

- Юун бөгж? – гэж Сэм - өөдөөс нь асуугаад - Чи гараараа Үдшийн гялаан руу заасан, тэр од чамайг маш хурц гэрэлтүүлсэн, гэвч би ямар ч бөгж хараагүй, юун бөгж яриад байгааг чинь ойлгохгүй л байна шүү. Гэвч нэгэнт чи надаас асуусан болохоор би эзэнтэйгээ хамт чамаас гуйя – Дайсны энэ бөгжийг авч үз! Хэрэв энэ бөгж чиний гарт очвол хэн ч чиний хүсэл зоригийг эсэргүүцэж чадахгүй! Чи энэ ертөнцөд дэг журам тогтооно шүү дээ. Хар муу үйлтнүүд Исторбинкийг сүйтгэж, миний муу өвгөнийг гудамжинд хөөж гаргахгүй шүү дээ. Тэд өөрсдөө ханаж цадталаа шангаа хүртэнэ!

- Тийм ээ, би тэднийг хазаарлаж чадна. Гэвч дараа нь... – гэж Галадриэль бодлогошрон өгүүлснээ – Ингэхэд бөгж Фродод үлдэнэ, тиймээс энэ тухай ярихаа больё. Явцгаая, та нарыг Лориэний эзэн хаан хүлээж байна.

Бүлэг 20

Лориэн минь баяртай

Хадгалагчид бүгдээрээ Эзний өргөөнд цугларав. Мэндэлсний дараа Селербэрн:

- Хадгалагчид хөдлөх цаг боллоо. Та нарын өмнө дахиад л сонголт нээгдэж байна. Аяллаа үргэлжлүүлэхээр шийдсэн нь маргааш Кветлориэнээс явах ёстой. Хадгалагчтай цаашид хамт явахыг хүсээгүй нь одоохондоо манай энд чөлөөтэй байж болно. Гэвч ДАЙСАН бөгжийг гартаа оруулах юм бол эльфийн зочид дайнд орно, бид Тэнгис рүү нэвтэрч орохыг хүсч байгаа, энэ дайнаас цөөхөн хүн амьд гарах болно.

Бүгд дуугүй суув.

- Тэд аяллаа үргэлжлүүлэхээр шийдсэн байна - гэж Галадриэль зочдыг тойруулан хараад хэлэв.

- Миний хувьд бол энэ аялал гэр рүүгээ явж байгаа хэрэг. Миний сонголт хялбар – Боромир хэлэв.

- Хадгалагчид Минас-Тирит рүү явах гэж байгаа гэсэн байх аа? – гэж Эзэн асуув.

- Бид хаашаа явахаа хараахан мэдээгүй л байна. Гэндальф энэ талаар нэг ч үг хэлээгүй. Миний бодоход тэр Кветлориэнээс цааш хаашаа явах талаар бодож амжаагүй байх – гэж Арагорн хариуллаа.

- Өмнө чинь Андуин байгаа, мөрнийг зөвхөн завиар л гатална, учир нь Осгилиатын гүүрнүүд бүгд байхгүй болсон. Хэрэв та нар Минас-Тирит орно гэвэл баруун эргээр явж болох авч зүүн эргээр явбал арай дөт. Та нар аль замыг нь сонгох вэ?

- Гондорыг дайрч гарах зам арай урт боловч аюул багатай - гэж Боромир хэлэв. Арагорн дуугарсангүй.

- Та нар хаагуур явахаа шийдээгүй юм байна. Гэвч би та нарт хаагуур явахыг хэлж өгөхгүй. Би арай өөрөөр та нарт тусалъя. Зарим хадгалагчдад завь сонин биш: Боромир, Леголас, Арагорн...

- Бас нэг хоббит! Манай тойрогт Брендидуим мөрөн урсдаг, мөрний завь гэдэг бол... унасан хүнийг унагаах гэж улайрдаг зэрлэг гүү биш гэдгийг би мэднэ – гэж Мерри хэлэв.

- Их сайн байна найз минь. Би та нарт лориэний завь өгье. Манай завинууд жижигхэн, хөнгөн, бат бөх. Тиймээс та нар айх аюулгүй хөвж болно, голын эргээр завиа өргөөд явж болно. Андуин олон салаатай, явган явах завиар хөвснөөс ядаргаатай, гол нь та нар Их мөрнөөр хөвж явахдаа хаашаа эргэх тухайгаа тайван бодох боломжтой – дорно зүг, Мордор руу юу, эсвэл өрнө зүг Гондор руу юу?

Арагорн багаа мөрний аль эргээр авч явахаа шийдэж чадаагүй байсан учир завинуудтай болсондоо маш их баярлав. Бусад хадгалагчид ч сэргээд явчихлаа. Тэдний өмнө маш аюултай аялал байгаа, үүнд тэдний нэг нь ч эргэлзэхгүй байлаа. Гэлээ ч гэсэн аюулын өөдөөс явган алхсанаас завиар хөвсөн нь хавьгүй дээр байв. Ганцхан Сэм л баргар царйлж суув. Тэрбээр голын завь зэрлэг гүүнээс хамаагүй аюултай гэдэгт итгэлтэй байв. (ерөөсөө зэрлэг гүү хэмээх амьтан байхгүй гэж тэр бодож байв).

- Бид завинууд болон аяны бусад хэрэгслийг маргааш гэхэд бэлэн болгоно. Одоо орой болсон тул та нар амарцгаа. Сайхан нойрсч, сайхан зүүд зүүдлээрэй! – гэж Эзэн ерөөв.

- Сайхан амарцгаарай, - гэж Галадриэль ерөөгөөд, - замаа ч сонгож амжина. Магадгүй та нарт хувь заяаны чинь сонгосон замыг өөрөө мэдэлгүйгээр сонгож эхэлсэн ч байж магадгүй - гэлээ.

Хадгалагчид усан оргилуурын дэргэдэх майхандаа цугларав. Хатан хааны үг тэднийг тийм ч их тайвшруулаагүй учир зөвлөгөө хийхээр шийджээ. Галт уул хүртэл хаагуур явах вэ гэж аянчид нэлээд удаан, халуухан хэлэлцээд, тэд бараг бүгдээрээ Мордороос айж байна, Хар эзний аймшигт ичээнд орохоо ядаж нэг хэсэгтээ хойшлуулахын тулд бүгдээрээ Минас-Тирит рүү явахыг хүсч байгаа нь тов тодорхой болов. Хэрэв Фродо Андуин мөрний цаана гаръя гэж хэлбэл бүгд айдсаа давж чадах байсан боловч Фродо ус балгасан мэт дуугүй суух тул тэд шийдвэр гаргаж чадахгүй байв.

Гэндальф тэдэнтэй хамт байсан бол Арагорн Гондор руу ямар ч эргэлзээгүй явах байлаа. Учир нь Элендилийн удам бүх нийтийн дайсантай тулалдахаар дайнд мордоно гэсэн эртний дунаданчуудын домгийг Боромирийн мэргэн зүүд баталж байна хэмээн баттай итгэх байсан юм. Гэвч Гэндальф үгүй болсон, тиймээс Фродо мөрнийг гаталъя гэвэл түүнийг дагахаас өөр замгүй гэдгийг Арагорн ойлгож байв. Гэвч Харанхуйн хөшгин доогуур сохроор мөлхөж ороод тэр хоббитод юугаар тусалж чадах сан билээ?

- Би Минас-Тирит рүү ганцаараа ч хамаагүй явна, энэ бол миний үүрэг - гэж Боромир хэлэв. Тэгээд Фродогийн санааг унших гэж байгаа юм шиг түүн рүү эгцлэн ширтэв. Мань хоббит дуугарах бодолгүй байгааг Боромир ажиглаад бодлогошронгуй доош харж, яриагаа үргэлжлүүлэв: - Хэрэв бөгжийг устах шаардлагатай л юм бол зэвсгийн хүчээр юу ч хийж чадахгүй, тэгэхээр хадгалагчдад Гондор руу явах хэрэг байхгүй. Гэвч Дайсныг устгах шаардлагатай юм бол... татгалзах нь тэнэг хэрэг... – гээд Боромир дуугүй болсноо урьд нь өөрөө өөртэйгээ ярьж байгаад одоо бусдад ярьж байгаагаа мэдсэн юм шиг яриагаа бодсоноосоо шал өөрөөр дуусгав: - Агуу их Гондорын тусламжаас - /Боромирын үг Фродогийн сэтгэлийг түгшүүлэв/ - татгалзах нь тэнэг хэрэг гэлээ... Юунаас? Бүгдийг захирагч бөгжнөөс үү? Элрондын болсон зөвлөгөөн дээр тэр энэ тухай ярьж байсныг, гондор баатарт Элронд бүгдийг тайлбарлаж өгөхөд ойлгох шиг болсныг Фродо санав. Хоббит найдвар тээсэн нүдээр Арагорн руу харвал цаадах нь бодолдоо дарагдаад Боромирын яриаг сонсоо ч үгүй бололтой. Зөвлөгөөн ингээд дуусав. Мерри, Пин хоёр аль хэдийн унтаж, Сэм унтахгүйг хичээвч нууцханаар эвшээж харагдав. Агаарт үүрийн өмнөх сэрүүн үнэр сэнгэнэж байлаа. Фродо хөнжилдөө ороод нам унтав.

Өглөө нь тэд замдаа гарахаар бэлдлээ. Эльфүүд тэдний майханд хувцас хунар, хэдэн жижиг

шуудай хүнс авчирч өглөө. Гимли нэг шуудайны амыг тайлаад, нимгэхэн хүрэн бин гарган ирж дундуур нь нугалтал дотроо кремтэй ажээ. Тэр амсаа ч үгүй байхдаа “галет л байна” гэж сэтгэл дундуурхан хэлэв. Гэвч амсч үзсэнээ нүд ирмэх зуурт бинг зажлаад залгиж орхилоо.

- Одоо боль! – гэж эльфүүд инээлдээд – Одоо чи орой болтол өлсөхгүй, гэхдээ бүтэн өдөр ажилласан ч ядрахгүй.

- Амьдралдаа ийм сайхан амттай галет идэж үзсэнгүй, үнэхээр гайхамшиг! Нуурын хаант улсын хүмүүс аян замын галет хийхдээ тун ч гарамгай, гэхдээ танай галетын дэргэд тэднийх юу ч биш юм байна – гэж Гимли хүлээн зөвшөөрөв.

- Манайд галет гэдэггүй, путлиб гэдэг юм, нийтийн хэлээр бол аяны талх гэсэн үг. Хэрэв бүтнээр нь байлгавал хэдэн долоо хоног ч шинээрээ байдаг. Тиймээс хоолгүй болох өдөр ирнэ гэж бодоод хадгалах хэрэгтэй. Аян замд яваа хүн бүтэн хоногт нэгийг идэхэд л өлсөх ч үгүй, ядрах ч үгүй – гэж тэд тайлбарлав.

Дараа нь хувцаснуудаа гаргаж ирлээ. Хөнгөн, нимгэн, маш бөх эдээр оёсон лориэний юүдэнтэй урт цувьг хүн бүрт тааруулан бэлтгэжээ. Тэдгээр цув аварга нарснуудын тунгалаг сүүдэрт солонгорсон мөнгөлөг өнгөтэй үзэгдэж байсан бөгөөд орчныхоо өнгийг шингээх чанартай тул нарны гэрэлд алтарч, ногоон дотор ногоорч, үүлгүй тэнгэрийн дэвсгэрт цэнхэртэж, бүрэнхийд бүдэг саарал, харанхуйд хар болдог ажээ. Хадгалагчид эльфүүдийг үзэгдэж харагдахыг хүсээгүй үед нь харах маш хэцүүг /огт чимээ гаргалгүй явдаг/ нэг бус удаа ажиглаад ихэд гайхдаг байсан тул тэр бэлгэнд маш их баярлав.

Цувны зах, юүдэн хоёрыг алтан судал бүхий навчны хэлбэртэй ногоолин товчоор товчилжээ

- Энэ илбэтэй юу? - гэж Пин шинэ цуваа баяртайгаар үзэнгээ асуув.

- Бид “илбэтэй” гэдэг үгийг ойлгодоггүй. Чиний цув бол эльф цув гэдэгт эргэлзсэний хэрэггүй... эльф гэдэг чинь та нарын хэлдгээр илбэ гэсэн утга. Ариун хязгаарын ус агаар, чулуу шороо, мод ургамал үүнийг солонгорсон олон өнгөтэй, бат бөх, зөөлөн, сайхан, мөнхийн болгосон юм. Яагаад гэвэл эльфүүдийг хүрээлж байгаа юм бүхэн урчуудынх нь бүтээлд шингэдэг юм. Цув бол дайчид, тагнуулчдын хувцас, дайсны сумнаас дайчдыг зэр зэвсэг нь биш, цув нь л хамгаалдаг юм. Хүйтэн, халуунаас ч хамгаална, салхи, борооноос ч хамгаална, дайсны нүднээс ч нууна. Урьд нь гадаад орны нэг ч хүнд лориэний хувцас бэлэглэж байсан удаагүй, та бүхэн Эзний сайн андууд болсон учир ийм бэлэг авч байна.

Энэ хооронд хөдлөх цаг болсон байв. Хадгалагчид майхан руугаа гунигтайгаар эргэж харцгаалаа. Тэд усан оргилуурын дэргэд, Эзний өргөөний дэргэд энэ майханд хичнээн хоносноо огт санахгүй байв... Эргэж хараад тэд Хэлдарыг харав. Фродо танилыгаа хараад маш их баярлалаа.

- Би умард хилийг хамгаалж байгаа, гэвч намайг сая та нарын газарчаар томиллоо, Галадхэнд би түр ирсэн. Хар голын хөндий утаагаар бүрхэгдсэн, газрын хэвлийд нүсэр доргион болж байна, ууланд ямар нэг таагүй явдал болоод байна, та нар умар зүг рүү явж чадахгүй болсон. Гэхдээ Андуин руу хүрэх зам одоохондоо чөлөөтэй байна. Явцгаая, цаг алдаж болохгүй – гэж

эльф дайчин хэлэв.

Мэллорнуудад эльфүүдийн дуу цангинаж байвч замд нь хэн ч тааралдсангүй, аянчид уул руу буугаад хаалгыг өнгөрч, хоёр хэрэмний хоорондуур явж, цагаан гүүрээр гараад Хэлдарын араас дорно зүг рүү чиглэн алхав.

Жим өтгөн ой дундуур сүлжиж, алтлаг навчис тэнгэрийг халхлан, аянчид налуу руу бууж яваагаа мэдэв. Арваад лиг яваад аварга нарснууд шингэрч тэнгэрт үд дундын нар гийж, аянчид алхаагаа хурдасган ойн цоорхойд гарч ирээд эргэн тойрноо харлаа. Тэдний баруун талаар тунгалаг уст Төлөгч гол дуу шуутайхан урсч, өмнө талд нь нүдний хараа үл хүрэм өргөн, дүнсгэр Андуйн чимээгүйхэн гулсч, бараантан нэлийх их усаараа тэдний замыг хөндөлсөн хаажээ. Хойт талд нь нарийхан нугыг аварга нарснууд хүрээлэн, Андуйны цаана овон товонт нуга, бут сөөг үргэлжилжээ. Төлөгч голын цаагуур уйтгарт нүцгэн ой тэнгэрийн хаяа хүртэл үргэлжилжээ. Энэ хоёр гол Ариун хязгаарын цэцэрлэгт газрыг өмнө, дорно талаас нь хашсан ажээ. Хадгалагчид Балар шугуйн хязгаарт дөхөж ирсэн нь энэ ажгуу.

Алтан төлөгчийн зүүн эрэгт Андуйнд нийлэх уулзвараас гучин алхмын зайд намхан цагаан чулуун зогсоол харагдах бөгөөд тэнд янз бүрийн өнгөтэй, том бага завинууд аргамжаатай байна. Эльфүүд хадгалагчдын ачааг гурван жижигхэн цагаан саарал завинд ачиж байлаа. Сэм эрэг рүү болгоомжтой дөхөж очоод, бөхийж эвхээстэй аргамж авч үзэв. Тэр нь маш хөнгөхөн, барьж үзэхэд торгомсог зөөлөн байв. Мань хоббит эльфүүдээс асуулаа:

- Энийг бас бидэнд өгч байгаа юм уу?

- Мэдээж, хангалттай байхын тулд бид завь бүрт гурван аргамж тавьсан. Ийм урт, хөнгөн, нарийн, баг бөх аргамжгүйгээр аянд хэзээ ч бүү гарч бай. Манай аргамж яг тийм. Та нарт нэг бус удаа хэрэг болно оо.

- Би мэдэхгүй юм аа! Бид Уудам хөндийгөөс аргамж авалгүй гарсан, тэгээд би Лориэнд иртлээ өөрийгөө зүхэж явсан юм...

- Хөдөлж болно, гэхдээ мөрөн рүү орох гэж битгий яараарай, эхлээд завьтайгаа дасах хэрэгтэй – гэж Хэлдар хэлэв.

- Тийм шүү тийм, болгоомжтой байгаарай, манай завинууд хэмжээнээс нь хэтэртэл ачсан ч их гүехэн суудаг, та нар үүнд шууд дасахгүй. Эхлээд эргийн дэргэд дасгал хий – гэж бусад эльфүүд анхааруулав.

Хадгалагчид завинуудад яаралгүйхэн суув. Эхлээд Фродо, Сэм, Арагорн гурав, дараа нь Мерри, Пин, Боромир гурав, тэгээд сүүлийн үед маш их дотносох болсон Гимли, Леголас хоёр шуудайтай хоол хүнсний нөөцөө авч суув.

Завины ёроолд өргөн навчны хэлбэртэй үзүүр бүхий сэлүүрүүд байлаа. Арагорн сэлүүр авч, анхны таталт хийн зогсоолоос гарч, эргийн дагуу өгсөн дасгалаа эхэллээ. Тэр маш чадамгай сэлүүрдэж байсан боловч урсгал хурдан тул завь удаан өгсч байв. Сэм урд талын буланд суугаад хоёр гараараа бүхээгийн ирмэгээс зууран, аварга их мөрөн рүү айдас дүүрэн нүдээр

ширтэнэ. Төлөгч наран дор хөгжилтэйеэ туяаран, завины хажуугаар нарсны навчис хөвнө. Аянчид төдөлгүй нугыг өнгөрч, тэдний дээрээс навчин бороо бууж, агаар хуурай сэрүүхнээр сэнгэнэн, зөвхөн бялзуухайнуудын жиргээ л орчны нам гүмийг эвдэж авай.

Арагорн завиа эргүүлж урсгалаар хөвөв. Гэнэт огцом эргэлтийн цаанаас асар том хун цасан цагаан хүзүүгээ бардмаар өргөсөөр нисэн гарч ирэв. Уянгалаг аядуухан хөгжим сонсдож, үзэгдэж харагдаагүй тэр шувуу дөхөж ирэхэд аянчид энэ бол огт хун биш, эльфүүдийн гайхамшигт ураар бүтээгдсэн завь болохыг ойлгов. Завь ер бусын том боловч холоос яг хун шиг харагддаг ажээ. Цагаан саарал цувтай хоёр сэлүүрч яг нэг хүн шиг нэн уран ажиллаж, дээгүүр нь өргөн жигүүр дэлгэжээ. Завинд Лориэний эзэн хаан сууж байх агаад, дэргэд нь Галадриэль суужээ. Өндөр гоолиг, цагаан өмсгөл, мөнх амьд цэцгийн алтан титэмтэй хатан хаан арфа хөгжим аялгуулан дарж, эльфийн гунигт дууг аялж байна. Тэр аялгуу гунигтай боловч амттайхан ажгуу:

Хаврын алтлаг навчсын тухай дуулнам би,

Хөглөгөр ой шуугин түрлэг нэмнэ,

Салхины тухай дуулнам би,

Нугын торгон ногоон дундуур шургаж, салхи шуранхай нэмнэ.

Тэртээ холхи хязгаарт сарны мандал гийжээ.

Тэнгисийн давалгаа түүний дээгүүр хөөцөлдөнө.

Гэрэлд бялдсан хөндийн дундах Эльдамарт

Тэргүүн бардам, аварга Илмарин сүндэрлэнэ.

Өшөө сануулагч бүрэнхийд гинжлэгдсэн уулсын дунд

Гэгээн Тирион гал мэт гэрэлтэн дээш цоролзоно.

Гээгдсэн очис мэт Цагаан модны мөчир дээр

Шүүдрийн дусал болгонд нь бидний нулимс асна...

Өө, Алтан Лориэн минь ээ! Энд би хэтэрхий удав биш үү.

Үхэх үйлтнүүд, тэдний өдөр хоногоор хүрээлүүлэн

Үүрийн Туяа мэт бидний урьдын амьдрал байж магад

Үл мэдэгдэх тэр Хязгаар луу зорчих хөлгийн тухай

Өчүүхэн ч найдвар өвөрлөлгүй дуулнам би...

- Бид хоёр та нарын аюултай бөгөөд хүнд бэрх аян замд тань амжилт ерөөхөөр ирсэн юм - гэж Галадриэль дуугаа дуулж дуусаад уянгалуулан хэлэв.

- Та бүхэн эльфүүдийн оронд олон хоног зочилсон боловч бид нэг ч удаа хамтдаа зоог барьж байсангүй. Хатан хаан та бүгдийг Хилийн агуу их мөрний эрэгт үдэлтийн зоогт урьж байна – гэж Селербэрн мэдэгдэв.

Фродо хоол умдаанд бараг гар хүрсэнгүй. Тэрбээр Хатан хааныг гунигтайяа ширтэж, энэ бол бидний эцсийн уулзалт гэж мэдэрч суулаа! Хатан хаан нөгөө л мөнхийн гоо үзэсгэлэнтэй хэвээр авч хүчирхэг, сүрлэг харагдсангүй. Харин ч аль дивангарт улирч баларсан эриний хэзээ ч өөрчлөгдөшгүй орь залуу, мөнхийн гоо сайхан хэвээр байв.

Зоогийн дараа Лориэний хатан хаан мөрний сав газрын талаар хадгалагчдад ярьж өгөв

- Андуин мөрөн ой, чулуурхаг талын хоорондох хавцал дундуур урсдаг юм. Эхлээд зүүн тийш огцом эргэж, дараа нь хэд хэдэн том эргэлт хийгээд өмнө зүг рүү улам нарийсан тэмүүлж, үржил шим муутай нэг багавтар уулын дундуур гарч, нэлээд огцом уруудаад Тол-Брандир буюу танайхны хэлээр Хясаат руу хоёр салаалж ордог, тэгээд Болонийн хөндий рүү орно. Хясаатын хүрхрээ рүү орох боломжгүй учир та нар эргээр тойрох болно. Гэвч Минас-Тирит рүү явья гэвэл Андуиныг орхин, Болонийн намагт хонхорыг тойроод Ристанийн тал руу орох хэрэгтэй. Харин баруун хойш эргэж, Манант уулын өмнө үзүүрийн ой руу орох хэрэггүй шүү. Тэр ойн талаар хачин домог цөөнгүй байдаг юм.

- Сүүлчийн удаа Уудам хөндий орох замдаа Мустангримийг хөндлөн гарсан. Би Цагаан Уулаас Саарал гол, Догшин гол хүртэл баруун газраар явсан боловч Гондор орох замыг зүүн талаас нь олж чадна... – гэж Боромир хэлэв.

Гондор баатар цааш ярих гээгүйг ажиглаад Галадриэль босч, ёслол төгөлдөр хэлэв:

- Эхэлсэн аянаа амжилттай дуусгахыг бэлгэдэж бүгдээрээ хундагаа тогтооцгооё! – гэлээ.

Хадгалагчид хундагаа хоосолсны дараа эзэгтэй тэднийг суухыг хүсээд:

- Бид одоо удаан хугацаагаар салах гэж байна. Гэвч та бүхэн Лориэнийг орхин одохын өмнө эльфүүдийн үдэлтийн бэлгийг авна уу – гэв.

Хатан хаан эхлээд Арагорнд хандаж:

- Хадгалагчдын отрядын удирдагч чамд манай мастерууд домогт Элендилийн илдэнд яг тохирох хуй урласан юм. Энэ хуйнаас сугалсан илд хугарах ч үгүй, ир нь мохох ч үгүй... удахгүй бидний хооронд Харанхуйн хар хөшиг хөндөлсөнө. Тэгэхлээр чамд зөвхөн Ариун хязгаарын эльфүүдийн хатан хаан би л биелүүлж чадах нандин хүсэл байна уу?

Арагорн хатан хаанд хандаж:

- Хатан хаантан минь, миний хүслийг зөвхөн миний зам – харанхуй дундуур ялалт эсвэл мөхөлд хүрэх зам л хөтөлнө. Ирээдүйн амьдралын тухай миний бүх бодол санаа Уудам

хөндий болон Лориэний эльфүүдтэй холбоотой, гэвч миний нандин хүслийг чи ч, Элронд ч биелүүлж хүч хүрэхгүй...

- Яаж мэдхэв дээ, ямар ч гэсэн бас нэг бэлэг ав – гээд Хатан хаан Арагорнд тунгалаг ногоон өнгөт эрдэнийн чулуун зүүлт өгөв. Жигүүрээ дэлгэсэн бүргэдийн дүрстэй тэр зүүлт навчны цаанаас гэрэлтэх нарны туяа адил зөөлөн гэрэл цацруулж байлаа. – Би энэ чулууг ээжээсээ өвлөж авсан юм, тэгээд охин Селебрайндаа бэлэглэсэн, охин маань охиндоо бэлэглэсэн, одоо чинийх боллоо. Учир нь цагаа болохоор чи Элендилийн омгийн Эльфийн Сувд Элессар нэртэй болно гэдгийг зөгнөөд хэлчихсэн байгаа.

Арагорн гүнээ мэхийн ёслоод зүүлтийг авч энгэртээ зүүв. Тэгтэл тэр гэнэт жинхэнэ эзэн хааны дүртэй болж хувирахыг бүгд харлаа. Тэрбээр хамгийн аюултай Балар шугуй дундуур аялсан олон жилийн хүнд ачааг мөрөн дээрээсээ аваад хаячих мэт Фродод санагдав.

- Селебрайн, Арвен хоёрт амьдрал бэлэглэсэн чамд Лориэний хатан хаан талархаж байна – гэж Арагорн хэлэхэд хатан хаан дуугүй мэхийв.

Пин, Мерри хоёрт Галадриэль цэцгэн хэлбэрт сүлжээстэй мөнгөн бүс, Боромирт болор шигтгээтэй алтан бүс, Леголаст маш уян мөртөө асар хүчтэй лориэн нум, нарийхан мөртөө хүнд сумтай саадаг бэлэглэв.

- Миний хөөрхөн цэцэрлэгч чамд онцгой бэлэг бэлтгэсэн, даруухан боловч их ашигтай бэлэг гэж бодож байна – хэмээн хатан хаан Сэмд эелдэг зөөлнөөр хэлээд, таган дээрээ ганцхан үсэг товойлгон сийлсэн жижигхэн хайрцаг өгөв. – Энэ үсэг бол рун бичгийн Г үсэг, хайрцаг дотор би ямар ч газарт өгөөмөр үржил шим өгөх жаахан хөрс адислаж хийсэн юм. Энэ жаахан шороо чамайг аян замд тохиолдож болох аюул, дайсны илд, сумнаас хамгаалахгүй боловч хэзээ нэгэн цагт гэртээ харихдаа аль хэдийн хоосорч хаягдсан газрыг ч үүгээр бордвол ер бусын хурдан цэцэглэн дэлгэрнэ. Тэр цагт чи Лориэн орныг санах байлгүй дээ.

Сэм байдгаараа улайж, талархлын эв хавгүй хэдэн үг бувтнан эльфүүдийн хатан хаанд гүнээ мэхийн ёслов.

- Эльфүүдийн тухай дурсах ямар бэлэг авбал гном баатарт таалалтай байх бол – гэж Галадриэль асуухад Гимли:

- Ямар ч бэлэг хэрэггүй ээ, Хатан хаан минь, Ариун хязгаарын үзэсгэлэн төгс хатан хааныг өөрийн нүдээр харсан минь надад хангалттай бэлэг – гэлээ.

- Та нар сонсов уу, хөөе? – гэж эльфүүдээс асуугаад – Гном бүхэн дүнсгэр царайтай, ашиг хайгч гэж бодогоо та нар одоо болих байх гэж би бодож байна. Гэхдээ бид чамайг бэлэггүй явуулахгүй шүү, эрхэм Гимли минь, чи Ариун хязгаарын эльфүүдийн дурсгал болгож ямар бэлэг авахаа хэлчих.

- Би юу ч гуйхгүй Хатан хаан минь – гэж мань гном хэлээд хэсэг дуугүй сууснаа гэнэт зориглож:

- Хэрэв хэзээ ч биелшгүй хүсэл биелдэг сэн бол... би Лориэний хатан хааны үснээс нэгэн туг авах сан. Гномууд үнэт эрдэнэсийг үнэлж чаддаг юм, чиний үсний дэргэд шижир алт зэвгэй төмөр болно! Бүү хилэгнээрэй – би юу ч гуйгаагүй байна... – гээд тэр таг дуугүй болов.

Эльфүүд эмээн шивнэлдэж, Селербэрн мань гном руу ихэд гайхан харав. Гэвч хатан хаан түүнээс зөөлөн дуугаар:

- Чи ийм бэлгийг яах байсан бэ?

- Лориэний эльфүүдтэй найрамдаж нөхөрлөсний дурсгал болгож, хамгаас эрхэм бэлэг болгон нандигнан хадгалах байсан – хэмээн гном баатар шууд хариулав.

Хатан хаан үснээсээ нэгэн тугийг авч түүнд өгөөд:

- Би юуг ч урьдчилан хэлэхгүй, учир нь дундад газарт Харанхуй ойртож байна, ирээдүйд юу болохыг бид мэдэхгүй байна. Гэвч Харанхуй сарних юм бол чи их алт олборлож чадна, гэхдээ алтны боол болохгүй - хэмээн бодлогошронгуй хэлэв.

- Хадгалагч чамд би хамгийн сүүлийн бэлгийг өгье – гээд хатан хаан Фродо руу харж: - Учир нь чиний аян замыг бага ч атугай хөнгөвчлөхийг аль эрт шийдсэн болохоор — хамгийн сүүлд өгч байгаа юм.

Хатан хаан босч, дотор талаасаа гэрэлтсэн болор аяга өгөөд: - энэ аяган дотор Үдшийн гялааны туяа туссан Толин цөөрмийн нэгэн дусал ус байгаа юм. Хичнээн харанхуй байна, төчнөөн хурц гэрэлтэнэ. Хэрэв чиний замд гэрлийн бусад эх булаг харанхуйлбал Эльфийн дэнлүү чамд тусална. Тэр цагт Галадриэлийг тольтой нь хамт дурсаарай!

Аяганы гэрлээр гийгүүлэгдсэн хатан хаан хүчирхэг, үзэсгэлэн гоо, агуу сүрлэг харагдаж байлаа. Фродо мэхийн ёслоод, бэлгийг дуугүй авлаа. Түүний толгойд хэрэгтэй үг орж ирсэнгүй.

Селербэрн хадгалагчдыг зогсоолд хүргэж өгөв. Жаргаж буй нарны ташуу туяанд Төлөгч голын мандал зөөлнөөр алтарч, тэнгэр бялзуухайн жиргээгээр цангинан байв. Аянчид дасгал хийсэн хувиариараа завинуудад хуваагдан сууж, эльфүүд завийг нь модоор хатган эргээс хөдөлгөөд аян замдаа сайн явах ерөөл хэлцгээлээ. Аянчид Их Андуин мөрөн рүү хөвлөө.

Андуин, Төлөгч хоёрын нийлэх уулзварын хясаан дээр лориэний хатан хаан дуугүй зогсч байлаа. Хөнгөн завинууд уулзвараас өнгөрч их мөрнөөр хөвөн одоход Лориэн эргэж буцахгүй өнгөрсөн үе рүү хөвөн одож буй алтан далбаат аварга хөлөг шиг алслав.

Агуу их дүнсгэр Андуин Төлөгчийн тунгалаг урсгалыг бараантуулан залгиж, завинуудыг өмнө зүг рүү хурдан урсгахад Галадриэлийн гэрэлт дүр төдхөн үзэгдэх төдий цэг болон жижгэрч, хоёр голын алган дээрх бяцхан дөл адил харагдав. Дөл гэнэтхэн бадрах мэт болсон нь Галадриэль өлмий дээрээ босон сүүлчийн удаа гараа далласан хэрэг байв. Дараа нь араас үлээх салхиар алсад дуулах аялгуу аяархан мөртөө тод сонсдов. Лориэний хатан хаан тэнгисийн цаадах эртний эльф хэлээр дуулж байсан бөгөөд аялгуу нь ер бусын сайхан дуурсч

байсан ч үг нь Фродогийн сэтгэлийг түгшүүлэв.

Аи! Лауриэ лантар ласси сУринен,

ЙЕни УнОтимэ ве рамар алдарон!

Йени ве линтэ йуадар а канцер

Ми оромарди лиссэ-мировОрева

Андунэ релла, Вардо желлумар

Нэ лоини йоссен тинтилар о элени

Омарьо апрет Ари-лиринен.

Си мон а йулма нин энквантума?

Ан си Тинталлэ Варда Оиолоссао

Ее фанйар тарьят ЭлентАри ортане

Ар Илье тиер РундулАве лумбуле;

Ар синданопрела кап-то морниз.

Си ванва нэ РОмэлло ванва, Валимар!

Намариэ! Нам хирувалио Валимар.

Наи эльо хирава. Намариэ!

Лориэний хатан хааны дурсан дуулсан тэр цаг үеийн үйл явдлууд болон дууны үг нь Фродод ойлгохын аргагүй хол байсан ч дууны утга агуулга түүний ой ухаанд тод үлджээ: “Салхи алтлаг навчсыг он жилүүд мэт тоо томшгүй алтлаг мөчрөөс хуулан шидэлж байна. Урт урт он жилүүд Тэнгисийн цаадах нугын дээгүүрх балын амтат агаар мэт улирч одлоо. Түүний дууны гэрэлт давалгаан дээгүүр, цэнхэр тэнгэрт одод жирвэлзэж, тэр, Варда оддыг бөхөөж, биднийг өвгөдийн минь эх нутгаас заагласан Тэнгисийг мөнхийн манан нөмөрлөө. Бид Валимараа үүрд алдлаа. Хагацъя, Валимар! Гэлээ ч бид чамайг олох итгэл найдвараа алдаагүй цагт бид үеийн үед хамтдаа байна!..”

Дундад газрын эльфүүд Заокийн хязгаар буюу Элберетийн хатан хааныг варда гэдэг байв.

Андуин дорно зүг рүү огцом эргэж, моддоор хучигдсан өндөр эрэг Ариун хязгаарыг Фродогоос зааглалаа. Тэр дахиад тэнд хэзээ ч очоогүй билээ.

Аянчид зүүн өмнө зүг хөвж байна. Жаргаж буй нар голын мандалд тусан ойж, тэдний

нулимст нүдийг гялбуулна. Гимли огтхон ч нуулгүй уйлж явав.

- Ариун хязгаарыг үзсэнээс хойш одоо би юуг ч сайхан гэж хэлэхгүй... Үдэлтийн бэлэгнээс бусад юуг ч гэсэн – гэж гном баатар нөхөртөө хэлэв. Тэр Галадриэлийн алтарсан туг үсийг хадгалсан хавтгай хайрцгаа хийсэн халаасаа тэмтэрч үзлээ.

- Би Мордор руу явах шийдвэрээ их хүчилж байж гаргасан, харин гол аюулыг нь мэдээгүй байжээ – гээд тэр нулимсаа арчиж, - Элронд аян замд чинь ямар сорилт тулгарахыг хэн ч мэдэхгүй гэж бидэнд анхааруулсан. Би Харанхуй дахь гай зовлон, гачигдал бэрхшээлээс айж байсан ч тийм зүйл намайг зогсоогоогүй. Хэрэв би Лориэнээс явахад ямар их тарчлахаа мэдсэн бол Уудам хөндийгөөс гэр рүүгээ буцах байлаа. Яагаад гэвэл дайсан маргааш намайг барилаа гэхэд өнөөдрийн салалтаас илүү тамлагааг тэр бодож олохгүйдээ... Би яасан золгүй амьтан бэ!

- Бидэнд бүгдэд нь хэцүү байна - гэж Леголас түүнд хэлээд – манай энэ цөвүүн цагт амьдарч байгаа хэн бүхэнд амаргүй байна. Бид цөм үнэтэй нандин юмаа алдана. Харин чамайг бол золгүй амьтан гэж хэлэхгүй шүү. Чи өөрийгөө алдаагүй байна – энэ л хамгийн гол юм шүү дээ. Хүнд үед чи андуудтайгаа хамт байна – аз жаргалын тухай юугаар ч булингартуулаагүй дурсамж чиний энэ насны чинь шагнал болно.

- Дурсамж? - гэж Гимли эргэлзэнгүй асуугаад – сайхан үг хэлсэнд чинь чамд баярлалаа, гэвч дурсамж гэдэг хэтэрхий хүйтэн тайвшрал. Тэр бол зөвхөн өнгөрсөн амьдралын толь шүү дээ. Ямар ч гэсэн гномууд тэгж боддог юм. Эльфүүдийн хувьд өнгөрсөн үе нь мөнх үргэлжилдэг, өнгөрсөн үеийн тухай дурсамж нь тэдний хувьд амьд амьдрал, харин бид байхгүй болсон юмыг дурсдаг, тиймээс бидний дурсамж хүйтэн байдаг... – гээд Гимли дуугүй болсноо гэнэт:

- За за, өөрийгөө зовоогоод яахав. Ярилаа гээд зовлон арилах биш... мөстэй усанд орсон ч ялгаагүй. Бид урсгалын яг дунд орчихсон байна шүү дээ – гээд тэр тухтайхан сууж аваад сэлүүрээ аван Арагорны завь харагдаж байгаа баруун эрэг тийш сэлүүрдэв.

Андуины хүчирхэг бараан ус хадгалагчдыг зүүн өмнө зүг рүү авч одов. Тэнд өвөл бүрэн ноёрхож байлаа. Хоёр талын эргээр нүцгэн модод чихэлдэж, аянчдаас эрэг орчмын газрыг хааж байв. Лориэнээс үлээх дулаан салхи алга болж, Андуин анир чимээгүйд хучигджээ. Шувуудын шулганаан хүртэл байхгүй. Бүүдийсэн нар ойн цаагуур далд орж, гол дээгүүр чийглэг хүйтэн үдэш болсноо төдөлгүй шөнийн харанхуй нөмрөв. Аянчид зүүн эрэг даган хөвж байлаа. Саарал хий үзэгдэл мэт нүцгэн модод тахир үндсээ усанд хомхойлон дүржээ. Фродо нэг л түгшүүртэй зүүрмэглэж, нүдээ ядрангуй анив.

Бүлэг 21

Их мөрөн

Фродо ойн цоорхойд сэрэв. Тэр хөнжлөөрөө сайтар хучсан боловч их даарснаа мэдрэв. Зэврүүн саарал өглөө болж байна. Ойн цоорхойг өндөр модод хүрээлж, хаа нэгтээ доор гол шуугиж байна. Хажууханд Гимли гал түлж байв.

Аянчид өглөөний цайгаа уугаад шууд хөдөллөө. Гэвч сэлүүрдэхийг хэн ч хүссэнгүй, завь урсгалаар намуухан хөвж байлаа. Тэд хаашаа ч эргэлээ гэсэн өмнө нь их аюул тосно. Хясаат уул хол байгаад тэд баярлаж байв. Тэнд хүрэх гэж хэн нь ч яарсангүй. Арагорн ч тэднийг яаруулахгүй гэж шийдсэн байлаа. Зөвхөн өглөөнөөс орой болтол сэлүүрдэж байх хэрэгтэй гэж л бодож байв. Учир нь тэд амарч байх хооронд Мордорын эзэн гараа хумхиад сууж байхгүй гэдгийг мэдэж байлаа.

Эргийн дагуух ой аажмаар шингэрч, гурав дахь өдөр бүр алга болов. Зүүн эрэг тэнгэр газрын савслага хүртэл үргэлжилсэн хүрэн өнгөт, амьгүй мэт харагдах толгодоор дүүрч, нүдний чилээ гаргах ганц шувуу, ганц мод бут, ядаж хадан цохио ч үзэгдсэнгүй. Аянчид Шидийн ширэнгээс Мөрний хөндийн уулс, Сөнөсөн намаг хүртэл сунасан Хүрэн тал хүртэл хөвлөө. Дайсан энд ямар муу үйл хийснийг нь, газрын гүний хүрэн гал дүрэлзүүлсэн үү, хар дэвхрэгнүүдээ тавьсан уу гэдгийг хэн ч мэдсэнгүй, Арагорн хүртэл мэдсэнгүй. Эндхийн газар аль хэдийн үхэж үгүйрчээ.

Бас л ойгүй болсон баруун эрэг өтгөн зэгсээр хучигдаж, ухаа хүрэн өнгөт зэгсэн шугуй салхинд намуухан гунигтай исгэрч байв. Зэгсэн шугуй дуусахад Фродо өндөр, өтгөн ургасан өвсөөр хучигдсан довцог бүхий нуга, түүний цаана алсын ойн зурвас, Манант нурууны бүүдгэр дүрсийг харав.

Зэгсэн дунд шувуудын жиргээ сонсдож, голын дээгүүр хаа нэг нугас нисэн, нэг удаа бүр хун ч харагдав.

- Хун! Бүр цоо эрүүл! – гэж Сэм хашгирахад:

- Хар хун, - гэж Арагорн дуугарав.

- Ямар ч хүйтэн, зэвүүн газар вэ дээ, өмнөд газарт хөгжил баясгалантай, бүх юм цэцэглэж, өвөл гэдгийг үздэггүй гэж би бодож байсан юмсан –гэлээ.

- Энэ өмнөд нутаг мөн гэж үү? -гэж Арагорн асуугаад - Андуины болон тэнгисийн эрэгт цэцэглэх цаг болсон, хэрэв өмнөд газрыг харанхуй сүүдэр нөмөрчихөөгүй бол тэнд одоо дулаахан, хөгжил цэнгэлтэй байх байсан гэж би бодож байна. Харин бид одоо дундад нутагт, Ристани гүрний умард хилд явж байна.

Энэ бол Хоббитаны өмнөд хилээс ердөө зуугаадхан лиг зайтай байдаг юм. Одоо энд цас орж ч магадгүй. Ристаний газар үржил шимээрээ алдартай, дээр үед энд оршин суугчид олон

байсан, гэхдээ одоо Андуины энэ хэсэгт хэн ч амьдардаггүй, учир нь өмнөд эргээр нь орхууд дахиад үзэгдэх болсон юм. Орхууд үй олноороо нүүдэллэж явдаг, замдаа тааралдсан амьд бүхнийг хүйс тэмтэрдэг, ристаничууд руу хүртэл дайрдаг гэж ярьцгаадаг юм.

Сэм эргэн тойрноо түгшүүртэйеэ харав. Урьд нь тэд ойгоор гарч явахад эргийн шугуй дотроос Дайсны тагнуулууд тэднийг ажиглаад байх шиг санагдаж байсан, одоо задгай тал дээр тэд ямар ч хамгаалалтгүй болсон шиг бодогдов.

Андуин өмнө зүг рүү огцом эргэлээ. Хоёр талын эрэг холдон тэртээ ард хоцорч, зүүн талын толгод намсан, баруун эрэг ширүүн өвс таруу ургасан нам газар болж, мөрөн улам өргөсөн тэлж, ус нь гүехэн болов. Салхи хуурайсч, хүйтэрлээ.

Аянчид хоорондоо бараг ярьсангүй, бүгд өөр өөрийнхөө бодолд дарагджээ. Фродо цэцэглэж байгаа Лориэн, хурц нар, тунгалаг аадар, алтан ой, мөнгөлөг голуудыг санаж явсан бол Леголас санаа бодлоо умар зүгт бэлчээж, зуны шөнө, цэнхэр гацуурт ойд сүүдэрлэгдсэн тариан талбай, оддын дор туяа цацруулсан горхины шулганаан, эльфүүдийн уянгалаг чанга дууг бодож явлаа. Гимли Галадриэлийн бэлгийг хадгалах хайрцаг хийх том, шүүдрийн дусал мэт тунгалаг очир эрдэнэ хаанаас олох вэ хэмээн санааширч явлаа. Мерри, Пин хоёр нөхдөө юу бодож явааг нь таах гэж оролдоно. Боромир ямар нэг юм бувтнан хумсаа мэрг, заримдаа Арагорны завин дээр гарч суугаад Фродо руу маш хачнаар харна. Сэм завиар аялах санасныг бодвол аюул багатай боловч уйдаж гүйцэх юм байна даа гэж бодно. Хөөрхий хоббит нэг л янзын уйтгарт эрэг рүү ширтэн сууж явлаа. Арагорн хайр тойрох болоход түүнд сэлүүрээ өгөхгүй байлаа.

Дөрөв дэх өдөр дуусч байлаа. Агаарт үдшийн манан бөөгнөрч, Сэм урьдын адил завины хушуун талд элгээ эвхэн суугаад арагшаа харж явав. Тэр завинаас бууж, хөл доороо хатуу газар мэдрэхийг туйлаас хүсч байв. Гэнэт тэр нуруугаа эгцлэн, нүдээ арчаад завины араас удаанаар хөвж байгаа гуалинг удаан гэгч харав. Дараа нь харц нь эрэг рүү халтирч, дахиад л зүүрмэглэв.

Тэр шөнө мөрний баруун эргээс холгүйхэн арал дээр буув. Оройн хоолны дараа Сэм хөнжлөөрөө сайн гэгч хучиж аваад унтаж эхэлсэн Фродод:

- Өнөөдөр энд буухаас хоёр цаг орчмын өмнө надад нэг хачин юм үзэгдэх шиг болсон... Үзэгдсэн юм болов уу, үгүй юм болов уу гэж бодоод л байна?

- Тэгээд үзэгдсэн юм уу, үзэгдээгүй юм уу? - гэж Фродо асуухдаа, Сэм ярих гэсэн юмаа заавал дуустал ярихаас нааш санаа амрахгүй гэж мэдэж байлаа. Олигтойхон яриадах, юу харсан юм бэ?

- Гуалин – гэж Сэм нууцгайлан шивнээд – зүгээр нэг гуалин биш, амьд, нүдтэй.

- Нүдтэй гуалин байдаггүй юм. Энд гуалин янз янзаараа бий, гэхдээ нүдтэй гуалин бүр энд хүртэл байхгүй – гээд Фродоо амттайхнаар эвшээв.

- Байна аа, би ч бас Гимлийн завины араас нэг гуалин хөвж байна гэж бодоод л өнгөрсөн.

Гэтэл тэр гэнэт хурдалж, биднийг гүйцээд ирсэн. Тэгэхэд л би нүдийг нь харсан юм. Гал шиг хоёр нүд гялалзаад байсан. Тэгээд харсан чинь амьд гуалин байсан. Тэр хунгийнх шиг хоёр сарвуутай, тэр сарвуугаараа сэлээд байсан... зүүд байсан юм биш байгаа? – гэж бодлоо. Нүдээ арчаад харлаа. Тэгсэн чинь нөгөө гуалин намайг ажиглаж байгааг мэдчихээд амьгүй юм шиг болчихсон. Нүд нь ч хөдөлдөггүй, сарвуу нь ч хөдөлдөггүй. Би түгшүүр зарлах гэснээ зүүрмэглээд зүүдэлсэн байж магадгүй гэж бодоод больчихсон. Дараа нь эрэг рүү харахад ямар нэг араатан уснаас үсрэн гараад модны цаагуур орчихсон. Та юу гэж бодож байна? Тэр юу байсан бэ?

- Зүүд ч биш юм шиг байна аа, тэр нүдийг би урьд нь харж байсан. Мориид ч харсан, Хар голд ч харсан. Биднийг Лориэнд байхад яг тийм нүдтэй амьтан бидний байрласан дэлонь өөд авирч байсан. Хэлдар ч бас тэрнийг харсан. Морийн орхуудыг устгасан эльфүүд бидэнд юу ярьсныг ч санаж байна уу?

- Саналгүй яахав, таны авга ахын яриаг ч санаж байна. Биднийг мөрдөж байгаа тэр этгээдийг би мэдэж байх шиг байна. Хорлум. Муу хараал идмэр, үхэж далд ороосой билээ!

- Би ч бас тэгж бодож байна. Балар шугуйгаас Мори руу зугтаад биднийг мөрдөж амжсан. Одоо ч мөрдөж байна.

- Яг тийм – гэж Сэм эзнийхээ үгийг зөвшөөрөөд – тэгэхээр бид маш өндөр сонор сэрэмжтэй байх хэрэгтэй биз дээ? Тэгэхгүй бол тэр муу үйлт нялцгай амьтан гэтэж ирээд багалзуурдаж алахад сарвуу нь чичрэхгүй. Одоохондоо Арагорныг сэрээгээд яахав. Та ч гэсэн унтаж амар. Би харуулд гаръя. Би завинд зүгээр л ачаа болж явдаг нэмэргүй амьтан учир өдөр нойроо авч болно.

- Ачаа-харуул – гээд Фродоо мушилзаж: - За яахав, чи шөнө дунд хүртэл харуулд гар, тэгээд юу ч болохгүй бол намайг заавал сэрээгээрэй.

Шөнө дунд Сэм эзнээ сэрээгээд ямар ч түгшүүртэй юм ажиглагдсангүй гэж илтгэв:

- Голд нэг юм салхийх шиг болсон, дараа нь эрэг дээр нэг юм саржигнасан, салхи, долгион байсан болов уу гэж бодож байна.

Фродо суугаад хөнжлөөрөө хучлаа.

Хадгалагчид унтацгааж байв. Эргэн тойрон нам гүм, цаг тун удаан явж, хоббитын нүд анилдаж эхлэв... Гэнэт завинуудын дэргэд ус цалгих сонсдож, хэн нэгэн уснаас маш болгоомжтой шумбан гарч ирэв. Завины ирмэгээс цайвар сарвуу зуурч авсан, сэлэгч амьтан завь руу өнгийж харснаа арал руу толгойгоо аажмаар эргүүлж харлаа. Фродо яг эрэг дээр сууж байв. Тэр гэрэлтсэн нүд, амьсгаадахыг тод сонсоод ухасхийн босч илдээ хуйнаас нь сугалав.... Гэвч гэрэлт нүд нүд ирмэх зуурт алга боллоо. Ус цалгих сонсдов. Фродогийн дэргэд Арагорн ирчихсэн зогсч байлаа.

- Юу болов?- гэж тэр шивэн асуулаа.

- Хорлум гэж Фродо товчхон хариулав.

- Чи тэрнийг мэддэг байх нь ээ? – гэж Арагорн гайхаад – тэр биднийг Морийн агуйд мөрдөж байсан. Одоо гуалин болж дагадаг болжээ. Би тэрнийг барих гэж оролдоод бүтээгүй. Тэр харх шиг шаламгай, могой шиг гулсамхай. Тэгэхээр тэрнээс дайжих хэрэгтэй, сул байхдаа тэр тун аюултай. Өөрөө ч сэм гэтэж ирээд алж чадна, дайснуудыг ч дагуулж ирнэ.

Тэр шөнө Хорлум дахиж ирсэнгүй. Хадгалагчид өдөр нь арал дээр амраад, үдэш нь дахин аялалдаа гарлаа. Одоо тэд өглөөгүүр унтахдаа заавал харуул гаргадаг болов. Нэг ч харуул Хорлумыг үзсэнгүй. Тэр ойртож ирэхээ больсон юм уу, хол хоцорсон юмуу бүү мэд. Хадгалагчид урьдынхаасаа хурдан хөвж, найм дахь шөнө хүртэл ямар ч адал явдал тохиолдсонгүй.

Цаг агаар хүйтэн, тэнгэр бүрхэг, зүүнээс салхи тасралтгүй үлээж байв. Орой болоход тэнгэр овоо цэлмэж, үүлсийн дундуур бүдэгхэн хавирган сар гарч ирлээ. Эрэг орчмын газар дахин өөрчлөгдөв. Андуины хоёр талаас хүрэн өнгийн бутан төглүүд шахаж, түүнээс цааш гүн хар ангалуудтай үелсэн хадан цохионууд цаашлах тусмаа өндөрсөн сүглийж, хааяа нэг үндсээрээ хадан цохионоос зуурсан хатангир хушнууд харагдана. Аянчид ристаничуудын Дайсны уул гэж нэрлэдэг Голын ууланд дөхөж ирлээ. Энэ хавийн газар тун ч муугаар зард гарсан билээ.

Хадан хясаануудын дээгүүр үй олон шувууд эргэлдэж, үүлэнд халхлагдсан нар хар хүрэн хясаануудын цаагуур далд орж байлаа. Арагорн тэнгэрийг хайнгадуухан ажиглангаа хорон санаат Хорлум Дайсны зарц нарт хадгалагчдын тухай мэдээ хүргэчихээгүй байгаа хэмээн санаа зовниж явлаа. Тэр гэнэт ухасхийн босов. Тэрбээр зүүн өмнө зүг рүү нисч яваа аварга том шувууг харжээ.

- Хүүе Леголас, чинийхээр бол энэ бүргэд мөн үү? – гэж тэр яаран асуухад нөгөөдөх нь сайн хараад:

- Бүргэд л байна, харин энд юу хийж явааг нь мэдэх юмсан. Бүргэдүүд зөвхөн ууланд л үүрлэдэг шүү дээ. Голын уул бол уул биш.

- Харанхуй болтол буудаллахгүй – гэж Арагорн хадгалагчдадаа шийдэмгий хэлэв.

Шөнө болоход дорнын салхи намдлаа. Андуиныг анир чимээгүй нөмрөв. Даржинхан сар дөнгөж гэрэлтэн, одод манан дунд бүдэгхэн жирвэлзэнэ.

- Хачин юм даа, сар хаа сайгүй нэг л баймаар юм. Энд Бөглүүд газарт ч, манай Хоббитанд ч ялгаагүй л баймаар. Гэтэл хоёр юм шиг санагдаад байх юм. Лориэнд өөрийнх нь сар, бусад газарт өөр сар байдаг юм шиг. Эсвэл би цаг хугацаанд бүрмөсөн төөрч орхисон юм болов уу? Биднийг эльфүүдийн нутагт ирж, анх удаа дэлонь дээр хоноход сар жижгэрч, баруун тийш хазайгаад долоо хоногоос хэтрэхгүй болов уу гэмээр харагдсаныг санаж байна уу? Бид Лориэнээс гараад долоо хоног хөвлөө. Өчигдөр намайг харахад дөнгөж сая төрсөн юм шиг нялх сар зүүн тийшээ хазайсан байсан. Тэгэхлээр цаг хугацаа байран дээрээ зогсоод байсан хэрэг үү? Бид эльфүүдийн нутагт гуч хоног зочлоогүй шүү дээ!

- Мэдэхгүй юм даа – гэж Фродо хариулаад – Эльфүүд цаг хугацааг захирдаггүй юм шиг байна, цаг хугацаа Лориэнд ч гэсэн явдаг юм шиг байна. Гэхдээ цаг хугацаа одоохондоо эльфүүдийг захирдаггүй юм байна. Тийм учраас Лориэнд байхад өдөр хоног өнгөрөхийг анзаардаггүй байжээ. Наина хатан хааны хүч агуу...

- Лориэний хязгаараас гадуур Наинагийн тухай хамгийн дотны найз нартаа ч, надтай ч гэсэн ярьж болохгүй – гэж Арагорн түүний үгийг таслав. Тэрбээр эргийг нэн түгшүүртэй нүдээр харж явлаа. Гэвч түгшүүр төрөхөөр зүйл ажиглагдаагүй учир Сэмийг хараад товчхон тайлбарлав: - биднийг Ариун хязгаарт байхад сар үхээд дахин амьдарч, дахиад үхэж байсан. Цаг хугацааг зогсоохгүй. Бид эльфүүдийнд гуч хоног зочилсон. Сүүлчийн найдварын хавар ойртож байна – гээд Арагорн дуугүй болж завинууд руу ойртов.

- Хөдөлцгөөе, энэ бол бидний сүүлчийн шөнийн аялал. Цаашаа би мөрний голдрилыг мэдэхгүй. Урсгал дагаж уруудахаар Сарн-Гебир буюу нийтийн хэлээр Уулын даваа тааралдана. Тэнд биднийг зайлшгүй барина. Өдөр гэрэлтэй цагт түүнийг эргийн жимээр тойрохын тулд эртхэн амарна. Гэхдээ Уул хүртэл эндээс наад зах нь зуун лиг байгаа. Энд хясаа юм уу, арал мөргөчихгүйн тулд их болгоомжтой явах ёстой. Тиймээс үргэлж миний араас дагаж явах хэрэгтэй.

Сэмийг харуулаар томилов. Манан сарниж, хурц одод Мөрний усыг очис цацруулан гийж байлаа. Усны мандал нүд гялбуулна. Сэм харанхуй руу анхааралтай харж байлаа. Шөнө дунд өнгөрч байв. Үл үзэгдэх эрэгт ус хад цохин шуугиж, урсгал улам түргэн болж байлаа. Сэм гэнэтхэн анхааруулах дохио өгөв. Тэдний өмнө замыг нь хаан баруун эргээс мөрний дунд хүртэл нарийхан чулуун хайр гараад ирлээ. Урсгал зүүн тийш огцом эргэж, завинуудыг зүүн эрэг рүү татлаа. Хөөсөрсөн ус хүржигнэн шуугиж, хоёр дахин нарийссан урсгал зүүн эргийн хясааг цохилон, хөөс бургиулсан усан эргүүлгүүд эрчилж байв.

- Шөнө энэ урсгалыг давж чадахгүй, хэрэв Уул араас нь залгавал биднийг бүгдийг нь нүдээ нээгээгүй муурын зулзага мэт живүүлж орхино – гэж Боромир буцахыг оролдох зуураа хашгирав.

- Баруун эрэг рүү сэлүүрдэцгээ! – гэж Арагорн завиа огцом эргүүлэнгүүтээ хашгирав. Гимли, Леголас хоёр араас нь эргэв. Арагорн сэлүүр дээрээ хүчлэн дарав.

- Би алдаж тооцоолсон байна. Бид Сарн-Гебир рүү яваад орчихлоо. Андуин миний бодсоноос хурдан урсч байна.

Аянчид урсгал сөрөн сэлүүрдсээр байлаа. Завинууд урагшаа удаан мөлхөнө. Тэднийг урсгал баруун эрэг рүү шахаж эхэллээ. Эрэг нэг л зэвүүн харлаж харагдана.

- Зүүн талаа барь! Биднийг хайрган дээр суулгаж, завь хөмөрч магадгүй гэж Боромир хашгирав.

Эрэг орчмын хайр чулуу завины ёроолыг шүргэж байгааг Фродо мэдрэв. Дараа нь ширүүн урсгалын бүдэгхэн хүржигнэх чимээг сумны исгэрээн зүсч, аянчид руу эргээс сум нисч ирэв. Нэг сум Арагорны юүдэнд тээглэв. Аз болоход мөрч амжиж бөхийжээ. Өөр нэг сум Фродог

онож, мифриль хөө хуягнаас нь ойж унав. Гурав дахь сум дундах завин дээр Меррийн сэлүүрийн үзүүрт тусав. Зүүн эрэг маш ойрхон байсан учир хар хясаан дээр хар дүрснүүд сүүтэгнэхийг Сэм харлаа.

- Ирчи! – Леголас эльф хэлээрээ дуу алдав.

- Орхууд! – гэж Гимли түгшүүртэй хашгирав.

- Хорлумын хийсэн ажил - гэж Сэм бувтнаад, -тэрнээс өөр орхуудыг дагуулж ирэх амьтан байхгүй. Хараал идсэн хар үйлтэн үхэж далд ороосой! Андуин хүртэл тэдний талд оржээ – зүүн эрэг рүү шахаад байна шүү дээ!

Хадгалагчид хамаг хүчээ шавхан сэлүүрдэв. Сумнууд тэдний толгой дээгүүр исгэрэн өнгөрч, ус цацруулан унаж байлаа. Гэвч дахиад нэг ч сум онож туссангүй. Орхууд харанхуйд маш сайн хардаг боловч хадгалагчдыг Лориэний цувнууд найдвартай хамгаалж байв. Лориэн цувгүй бол тэд балрах байжээ.

Завинууд удаан урагшилж байв. Төдөлгүй урсгалын хүч суларч, хадгалагчид мөрний дунд урсгал руу ороход баруун талын хавцал харанхуйд алга болов. Тэгээд тэд зүүн тийш огцом эргэж, эргийн бутнууд дотор нуугдаад, сэлүүрээ тавьж, түр амрав.

Леголас саадагнаасаа сум авч, үелсэн хясаа өөд жаахан авираад нумынхаа хөвчийг татан Мөрөн рүү харлаа. Гэвч харагдах юм байсангүй. Орхуудын орилолдоон ч тэгсхийгээд намдав. Фродо эльф баатрын доороос харж байлаа. Шөнийн тэнгэрт одод ирмэлцэж, өмнө зүгээс хар үүл наашлан мөлхөж, одод дараа дараагаар үзэгдэхээ болилоо.

Аянчид гэнэт айж эхэллээ.

- О Элберет! Гилтониэль, - хэмээн Леголас тэнгэр өөд харан шивнэв.

Өмнөөс нүүж байгаа үүлийг гүйцэн эртний үлгэрийн луу мэт аварга том далавчит хар сүүдэр аянчид руу ойртов. Андуины цаанаас баярлан бархиралдах дуу хадав. Фродо айсандаа хөдөлж ч чадахаа больж, Эргүүлэг уулан дээр нүднийх нь өмнө гялсхийсэн илдний үзүүр харагдах шиг болов. Тэр агзасхийн нүдээ анилаа.

Лориэн нумын хөвч тасхийн жингэнээд явчихлаа. Сум тэнгэрээр исгэрэн нисч, далавчит хар сүүдэр амь тэмцэх мэт чичирхийлээд, сөөнгө дуугаар хашгирснаа Андуины цаагуур алга болов. Тэнгэрт одод дахин гялалзаж, зүүн эрэгт орилолдоон нам болов. Хар нам гүмийг хэн ч эвдсэнгүй... Хадгалагчид сэлүүрээ авч, урсгал сөрөн удаан урагшиллаа. Удалгүй тэдний өмнө нарийхан булан гарч ирэв. Тэд булан руу орж, эрэгт хүрээд, тэнд өглөө болтол хүлээхээр шийдлээ. Гал гаргаж болохгүй учир эльфийн бингээр хүчээ сэлбэлээ.

- Лориэний нум, ойн эльфийн мэргэн нүд хоёрыг бурхан ивээтүгэй! – Гимли бингээ идэж дуусангуутаа ерөөгөөд – гайхамшигтай харвасан шүү, анд минь! –гэхэд Леголас:

- Би ямар амьтан харваснаа ч мэдээгүй – гэж чичрүүдсээ даран хэлэв.

- Би ч гэсэн ямар гээчийн юм бидэн рүү нисч ирснийг ойлгоогүй, тэрэнтэй учирна гэж бодоход баярлаагүй шүү, даан ч баярлаагүй. Яагаад ч юм надад Мории санагдсан... – гэж Гимли өгүүлээд эргэн тойрноо айсан нүдээр харснаа - ... Барлог, - хэмээн шивнэв.

- Энэ Барлог биш ээ, - гэж хар айдсаасаа салж амжаагүй байгаа Фродо хэлээд - Өөр л нэг юм байна. Барлог улайссан үүлтэй адилхан. Леголасын харвасан этгээд... над руу үлээсэн... – гээд Фродо агзасхийж - ... булшны хүйтэн амьсгалаар. Надад ... – гэснээ мань Хоббит түгдэрч дуугүй болов.

- Чамд юу гэж санагдсан юм бэ? - хэмээн Боромир Арагорны завь руу хазайж асуув.

- Зүгээр л нэг юм санагдсан юм, яриад байх ч юмгүй – Фродо хариултаас зайлсхийгээд - харин Леголас холбоотныг нь харвахад орхууд их л гонсойсон доо.

- Гонсойсон ч, хорссон ч. Харамсалтай нь бид тэдний санааг мэдэхгүй байна. Ямар ч байсан тулалдаанд бэлтгэ. Энэ шөнө бид унтахгүй – гэж Арагорн хэлэв.

Цаг хугацаа чимээгүй өнгөрсөөр. Алсад хүрхрээ шуугина. Мөрний цаана нэг л сэжигтэй нам гүм. Өмнөөс нүүж ирсэн хүнд үүл Андуиныг нойтон хөнжил мэт нөмөрчээ. Салхигүй, чийглэг дулаахан манан. Моддын мөчир дээр шүүдрийн дуслууд бүдэгхэн гялалзана.

Дорно зүгээс үүр гэгээрэхэд үүлэн дундуур шүүсэн мэт өглөө болж, ядарсан аянчдын нүднээ уйтгартай, хачин мөлийсөн орчинг үзүүлэв. Нэг ч үзэгдэх бараагүй, бараан сүүдэр ч үгүй, зөвхөн бүүдийсэн саарал манан. Зүүн эрэг үл харагдана.

- Би мананд дургүй. Тэгсэн чинь манан хүртэл хэрэг болдог юм байна. Орхууд одоо биднийг олж харахгүй биз дээ? – гэж Сэм асуув.

- Магадгүй, харахгүй ч байж болох юм, хэрэв бид эргийн дагуу Сарн-Гебирыг тойрч гарах жим олж чадвал... - гэж Арагорн хариулав.

- Бид одоо Андуин мөрөн, эргийн жимээр яах юм бэ? – хэмээн Боромир ярианд оролцож: - одоо энэ эльфийн завинуудыг орхих цаг болсон, нэгэнт энд ирсэн учраас баруун тийш зүглээд өмнө зүг рүү эргэж, Цэвэр ойг гатлах хэрэгтэй.

- Энэ бол Минас-Тирит хүрэх зам, бид хаашаа явахаа хараахан шийдээгүй байна. Өмнө зүг рүү хаагуур эргэхээ мэдэхгүйгээр Болоний намгийн дагуу алхана гэдэг мөрнөөр хөвснөөс аюултай. Чи дорнод Ристанийг мэдэхгүй шүү дээ. Харин мөрөн биднийг төөрүүлэхгүй – гэж Арагорн хэлэв.

- Манан сарнингуут биднийг зүйл дуусгана. Орхуудаас амьд саллаа гэхэд, Хясаат хүрлээ гэхэд цаашаа яах юм бэ? Хясаатыг даваад намаг руу эргэх юм уу?

- Хясаатыг бид эргээр тойрно, явах замдаа сайн харна. Чи эртний нуменорчуудын харуулын цамхаг Амон-велар, Амон-Слоушийг мартчихсан юм уу, санахыг хүсэхгүй байгаа юм уу? Тэр хавийн газрыг харж байгаад хаашаа явахаа шийдэж болно.

Боромир Арагорнтой нэлээн удаан маргав. Гэвч Фродо болон бусад нь Мөрний дагуу явахаар шийдсэнийг сонсоод:

- Гондорчууд андуудыг нь амаргүй зам хүлээж байгааг мэдсэн мөртөө орхиод явдаггүй. Би та нарт завиа авч явахад чинь тусална, дараа нь Хясаат руу хамт бууна. Тэнд орхууд маш аюултай. Гэвч дараа нь та нарт хэрэг болохгүй бол баруун зүг ганцаараа явна - гэлээ.

Доор манан бага зэрэг шингэрчээ. Арагорн, Леголас хоёр эргийн жимийг хайхаар болов.

- Орхууд гарч иртэл аянчид Андуинаар их урууддаг байсан юм, жим олоход хэцүү биш гэж бодож байна. Уулыг дандаа л тойрч явдаг байсан – гэж Арагорн хэлэв.

- Андуины хавиар орхууд тэнэдэг болсноос хойш мөрөн рүү хойт талаас нь орох боломж бараг байхгүй болсон, өмнө зүг рүү хичнээн гүн орно, төчнөөн аюултай болно – гэж Боромир анхааруулав.

- Өмнө зүг рүү бүх зам аюултай - гэж Арагорн тайван хариулаад – маргааш хүртэл эндээ хүлээж бай. Хэрэв энэ хугацаанд бид хоёр эргэж ирэхгүй бол удирдагчаа сонгоод шууд замдаа гар – гэв.

Леголас, Арагорн хоёр манан дундуур явж одохыг аянчид сэтгэл түгшин харж байв. Гэвч тэд сэтгэл түгших хэрэггүй байжээ. Тагнуулчид хоёр цаг орчмын дараа эргэж ирэв.

- Бүх юм хэвийн – гэж Арагорн ирэнгүүтээ зарлаад – эргээс жаахан дээхнэ Уулын цаагуур тойрон даваанд хүрэх жим байна. Бид бүтэн хагас лиг л явах юм байна. Даваа хүртэл хагас лиг. Өмнөд зогсоол хүртэл урсгал түргэн боловч хайр байхгүй. Жим эхэлж байгаа хойт зогсоол хүртэл нэлээд хол учир удаан сэлүүрдэнэ. Тийм учраас эндээс л дээш гарах хэрэгтэй. Гол нь завинуудаа гаргах байна. Эрэг эгц, хадархаг байгааг харж байгаа биз дээ.

- Энэ ч амаргүй дээ – гэж Боромир бувтнав.

- Гэвч бид дөнгөнө өө - гэж Арагорн хэлэв.

- Мэдээж дөнгөнө! – гэж Гимли хэлэв.

... Ачаагаа буулгах гэж аянчид нэлээд зүдэрсний эцэст буулгаж дууслаа. Эхлээд ачаагаа жим дээр гаргав. Дараа нь хэсэг амраад завинуудаа эрэг дээр гаргахад гайхмаар хөнгөн байна аа. Ямар модоор хийснийг Леголас мэдсэнгүй, бусад нь бүр ч мэдсэнгүй, тийм хатуу мөртөө тийм хөнгөн, бараг жингүй завийг Пин, Мерри хоёр хүртэл төвөггүй зөөв. Гэвч Боромирын тусламжгүйгээр жим хүртэл зөөж чадахааргүй байв. Хад асга, мөлхөө үндэс, хувцаснаас зууралдсан өргөст буттай гүн ангал, мөсөн горхи, гүн худаг зэрэг нь завь өргөсөн намхан аялагчдад туулахын аргагүй саад байлаа. Аварга хүчит Арагорн, Боромир хоёр хүртэл тэр хүнд саадыг нэлээн зүдэрч давсан ба завинуудыг жим дээр гаргаснаас хойш цаашаа хурдан явлаа.

Жим хүрэх замын баруун талаас тахиралдсан ан цавтай эгц хадан хана шахаж, зүүн талаас

Уулын давааны хадан дундуур шүүгдэн гарч ирсэн үл үзэгдэх гол хүрхрэн шуугина. Жим дээр заримдаа дээрээс нурж ирсэн том чулуунууд, заримдаа борооны уснаас үүссэн хонхрууд тааралдаж байсан бөгөөд тэдгээрийг тойрч гарахад хэцүү биш байв. Төдөлгүй жим зүүн тийш эргэж, байгалийн боомт болсон зогсоол руу буужээ. Эргийн дагуух явган аялал төгсч, цаашаа давахын аргагүй хясаа тулав. Энэ замаар аянчид хоёр удаа явж ачаагаа зөөв.

Тэр хооронд бүрэнхий болж, аянчид чулуун эрэг дээр суугаад уйтгартайхан амарлаа. Алсад Сарн-Гебир нэгэн хэмээр хүржигнэн аянчдыг үүрэглүүлнэ.

- За ингээд хүрээд ирлээ дээ, гэхдээ өнөөдөр бид хөвж чадахгүй. Бид сайн амрах хэрэгтэйгэж Боромир хэлэв.

- Хэрэгтэй – гэж Арагорн зөвшөөрсөн боловч - харин ханатлаа унтаж чадахгүй, учир нь хоёр хоёроороо харуулд гарна. Гурван цаг унтаад нэг цаг харуулд гарна гэсэн үг. Хэрэв манан өглөө болтол сарнихгүй бол бид дайснуудаас мултарч магадгүй – гэлээ.

Шөнө ямар нэг онцгой явдал тохиолдсонгүй, үүрээр бага зэрэг бороо шиврэв. Хадгалагчид үүрээр замдаа гарлаа. Манан бага зэрэг, аянчид баруун эргийг барин сүүн цагаан манан дундуур хөвлөө. Гурван цаг орчим явсны дараа бороо дусалж эхэлснээ тэр даруй хаврын аадар асгарав. Завиа живүүлчихгүйн тулд ус нэвтэрдэггүй нимгэн арьсаар хийсэн бүтээлгээр бүтээж, бараг таамгаар хөвж байлаа.

Аадар манангийн хөшгийг зад татаж, түргэн зуурт арилахад тэнгэр цэлмэлээ. Өрнө зүг рүү хар үүлс хөвнө. Голын уулын хөрөөний ир шиг хадан хана Андуиныг хоёр талаас нь шахаж, аянчдыг урагш эрчимтэй түрж байсан тул тэд эргэж, урсгалын эсрэг сэлүүрдэх боломж алга байлаа.

Фродо урагшаа түгшүүртэй харж явлаа. Хадгалагчид хүний дүрс санагдуулам аварга том хясаануудад тулж ирэв. Хүчирхэг, өндөр тэр хясаанууд Мөрний доод хэсгийг дайснуудаас хамгаалж буй чулуун дайчид шиг харагдана. Аянчид тэдгээрийн хоорондуур сэлүүрдэх хэрэгтэй болов.

- Энэ аваргууд бол Гуменорын хаант улсын агуу их вангууд – гэж Арагорн хэлээд – Миний араас! Урсгалаас бүү гараарай! Бие биеэсээ аль болохоор зайтай яв! – гэж хашгирлаа.

Чулуун аваргууд бүр ойрхон болов. Тэд өөрсдийг нь бүтээгчдийн өгсөн агуу сүрлэг дүр төрхийг олон зууны салхи шуурган дундуур хадгалж иржээ. Үг хэлгүй боловч агуу сүрлэг, өнө эртний боловч хүчирхэг, он цагийн салхинд ан цав гарсан дуулгатай тэр аваргууд нүдээ бага зэрэг онийсхийн умар зүг харж, зүүн гараа анхааруулах аястай өргөж, баруун гартаа байлдааны сүхээ чанга атгажээ. Догот хаант улсын агуу сүрлэг харуулууд Фродод айн сүрдэм санагдаж, тэдний сүүдэр аянчдыг нөмрөхөд дээш харах зориг хүрсэнгүй. Боромир хүртэл доош тонгойж, өнгөрсөн үеийн аварга харуулуудын дундуур үсрэн тонгочих завин дээрээ хүч мэдэн сэлүүрдэж байв.

Тэнгэр баганадсан эгц шовх хясаанууд хадгалагчдын хажуугаар түргэн зуурт өнгөрч, давалгаантай толь мэт хар ус чих дөжрөм хүржигнэж, салхи ясанд хүртэл хүйтнээр үлээж

байв. Фродо чичрэн суугаа Сэм рүү налж, түүний байн байн тасалдах үглээнийг сонсч байв:

- Амьд гардаг л юм бол... дахиад хэзээ ч... яасан ч... ойртож очихгүй... алсаас ч харахгүй...

- Бүү айгтун! – гэсэн хачин дуу гэнэт цуурайлав. Фродо эргэж хараад Тэнэмэлийг харсан боловч шууд таньсангүй. Түүний өмнө Бөглүүд ойн зүдэрсэн тэнүүлч биш, гоо сайхан, цэл залуу, хүчирхэг ван зогсч байлаа. Идэрхэг бардам, арагшаа хайнга буулгасан юүдэнтэй тэрбээр Андуины галзуу урсгалыг эмээллэсэн Лориэний завины хушуун дээр эх нутагтаа эргэж ирсэн эзэн хаан шиг харагдлаа.

- Бүү айцгаа! – тайван бөгөөд тодхон хэлэхэд Мөрний урсгалын хүрхрэх чимээ түүний дууг дарсангүй. – Олон жил би Чулуун аваргуудыг үзэх юмсан гэж мөрөөдөж байсан. Исилдур, Анарион хоёрыг. Тэд өөрийнхөө шууд удам – Элендилийн омгийн Араторны хүү Эльфийн Элессарт энэ урсгалыг давахад нь тусална. Бүү айцгаа. Энд бидэнд ямар ч аюул тохиолдохгүй.

Хадгалагчдын хөвж байгаа хавцал түргэн нарийсч, баруун тийш эргэхэд хоёр талаас шахагдсан урсгалын нэгэн хэмийн хүржигнээнийг хадан уулын цуурай улам ч сүрлэг болгож, улам харанхуйлсаар байлаа... Гэвч тэдний өмнө гэгээ гарч, хавцлын хананууд гэнэт холдоход аянчид амгалан тогтуун нуур руу орж ирэв. Сийрэгхэн хурган цагаан үүлтэй цайвар тэнгэр нуурын мандалд үл мэдэг чичирхийлэн тусна. Нар нэлээд хэвийжээ. Зуувин хэлбэрт нуурын хадархаг эрэгт хүчирхэг, бат бөх царснууд ургаж, салхи шуурганд тахирласан мөчрүүд нь наранд гялалзан байна. Алсад, нуурын өмнө захад налуу эргийн дээр гурван уул сүндэрлэж, дундах уулын хоёр талаар мөрөн салаалан оджээ.

- Энэ бол Тол-Брандир – гэж Арагорн дундах уул руу зааж: - Түүний зүүн, баруун талд эртний нуменорчуудын харуулын цамхаг: Амон-Слоуш, Амон-Ведар байна. Нийтийн хэлээр бол Сонор чих, Соргог нүд гэсэн үг. Нэгэн цагт тэнд харуулууд жижүүрлэж, дайсан ойртож байгаа эсэхийг чагнаж, хараачилдаг байсан юм... Гэвч, Тол-Брандирын арал дээр хэзээ ч, нэг ч хүн, нэг ч араатан байгаагүй гэж ярьдаг юм.... Арлын цаана Рэрос мөнхөд хилэгнэж байгаа.

Өмнө зүг рүү хөтөлсөн дөлгөөн урсгалд хадгалагчид хоолоо идэж, хэсэг амарлаа. Тэгээд сэлүүрээ авцгаав. Нар бүдэгхэн хүрэн өнгөөр туяарч, өмнө зүгт Хясаат уул бараантан Хясаатын хүрхрээний хүржигнээн тодхон сонсоно. Харанхуй болж байхад аянчид аралд дөхөж ирлээ.

Их мөрнөөр аялсан тэдний аяллын арав дахь өдөр жаргав. Бөглүүд газар ард нь хоцорлоо. Өглөө тэд баруун, зүүн зүгийн аль нэг рүү эргэнэ.

Бүлэг 22

Гарам

Арагорн тэднийг баруун салаа руу дагуулж орлоо. Овид, салаа хоёрын дунд нарийхан нуга байв. Түүнээс цааших газар харанхуйд үл харагдана. Арагорн эрэг рүү эргэж зогсов.

- Овидын ойролцоо орхууд үзэгдсэн гэж би нэг ч удаа сонсоогүй. Гэхдээ харуул гаргасан нь зөв – гэж тэр хэлэв. Хадгалагчид завинуудаа эрэг дээр гаргаад, хөнжилдөө ороод нам унтлаа. Шөнө түгшүүртэй явдал болсонгүй. Хүн бүр ээлжээр нэг цаг харуулд гарч байлаа. Хорлум болон орхууд үүр цайтал үзэгдсэнгүй. Хэрэв хорлум отрядын араас дагасан бол хаа нэгтээ нуугдсан биз ээ. Гэвч Арагорн сайн унтаж чадсангүй. Тэр үүрээр босч, дөнгөж сая Сэмийн халааг авсан Фродо дээр хүрч ирэв.

- Чиний ээлж хүртэл өдий байна, яагаад унтахгүй байгаа юм бэ? – гэж хоббит асуухад:

- Өөрөө ч мэдэхгүй байна. Нойрон дунд л нэг хачин түгшүүр төрлөө. Алив, чиний Тернийг нэг хараадахъя.

- Яах гэж? – хэмээн Фродо гайхан асуугаад - чи орхууд бидэн рүү гэтэж байна гэж чи бодоод байгаа юм уу?

- Хараадахъя – гэж Арагорн дахин хэлэхэд Фродо илдээ хуйнаас нь сугалав. Илдний үзүүр үл мэдэг гэрэлтэж байлаа.

- Орхууд! – гэж хоббит сандран шивнээд –Тийм ч их ойрхон биш, гэхдээ л ойртож байна.

- Хангалттай ойрхон байна – гэж Арагорн батлаад – гэхдээ зүүн эргээр тэнэж яваа Сауроны тагнуул ч байж мэдэх юм. Миний л мэдэхээр саяхан болтол орхууд Амон-Ведарын дэргэд үзэгдээгүй. Гэхдээ гондорчууд ухарснаас хойш мөрний сав газарт олон юм өөрчлөгдсөн л дөө. Бид одоо маш болгоомжтой явах хэрэгтэй.

Өглөөний гэгээ алсад асч байгаа түймрийн туяаг санагдуулав. Дорно зүгт бүдэгхэн нарны туяагаар гийгүүлэгдсэн хүнд хар үүлс хэсэг бусгаар бөөгнөрөн байснаа удалгүй нар цэлмэг тэнгэрт мандаж, Тол-Брандирын эрсхэн дүрийг алтруулан гэрэлтүүлэв. Фродо арлыг ихэд сонирхон ажиглав. Арал гүехэн урсгал дотроос эгц хадан эрэг үүсгэн гарч ирсэн байх бөгөөд эрэг дээр царсан төгөл ургаж, гол оргил нь нүцгэн хадан цохио байв. Арлын дээгүүр шувууд эргэлдэх боловч ямар ч араатан байсангүй, ядаж могой ч үзэгдсэнгүй.

Өглөөний хоолны дараа Арагорн нөхдөдөө:

- За нөхөд минь, бид одоо Дайсантай тулалдахаар баруун зүг – Гондор руу явах уу, эсвэл зүүн зүг рүү - айдас, харанхуйн орон руу явах уу гэдгээ эцсийн эцэст шийдэх цаг боллоо. Эсвэл хүн бүр өөрсдийн үүргээ биелүүлэхийн тулд тарж явах уу? Шийдвэрийг хойш тавьж болохгүй, яагаад гэвэл Андуины цаана орхууд тэнэж яваа – хэрэв тэд энэ эрэгт хараахан

гараад ирээгүй бол бид алгуурлавал амь үрэгдэх болно.

Арагорн дуугүй болов. Гэвч хадгалагчдын хэн нь ч нам гүмийг эвдсэнгүй, өчүүхэн ч хөдөлсөнгүй. Арагорн дахин ярьж эхлэв:

- Харваас сонголтын хүнд ачаа чиний л мөрөн дээр бууж байна даа, Фродо. Бид бүгдээрээ хадгалагч нэртэй, яагаад гэвэл чамайг дагалдаж яваа, гэвч бөгжний хувь заяаг чи ганцаараа хариуцна, яагаад гэвэл бөгжийг чамд мэргэдийн зөвлөл итгэж даатгасан, хаашаа явахыг чинь бид тодорхойлохгүй. Гол хадгалагчид зөвлөгөө өгөх эрх надад байхгүй. Би Гэндальфыг чадлынхаа хэрээр орлож яваа боловч Гэндальф биш, - тэр энд ирсний дараа ямар сонголт хийх байсныг би мэдэхгүй. Гэндальф энд байсан бол сонгох эрхийг чамд өгөх байсан гэж би бодож байна. Тийм ээ, Фродо, чиний үгийг сонсьё, чиний шийдвэр гол бөгөөд эцсийнх.

- Яарах хэрэгтэй гэдгийг би мэдэж байна – гэж Фродо удаанаар ярьж хэлэв: - Гэвч эцсийн сонголт гэдэг бол маш хүнд ачаа. Бодох нэг цагийн хугацаа өгнө үү Арагорн, би эргэж ирэнгүүтээ үгээ хэлье. Яагаад гэвэл би ганцаараа бодмоор байна – гэв.

- За за, ганцаараа бод доо, Дрогогийн хүү. Бид чамайг энд нэг цаг хүлээнэ. Харин чи хол битгий яваарай – гээд Арагорн түүнийг өрөвдөж, хайрласан нүдээр нэгэнтээ гүйлгэн харав.

Фродо хэсэг зуур толгойгоо тонгойн хөдөлгөөнгүй суулаа. Сэм эзнээ анхааралтай ширтэж байснаа хамар дороо:

- Би мэдээж дуугарахгүй. Бүх юм тов тодорхой байхад хэлээд байх юу байдаг юм бэ – хэмээн бувтналаа.

Сэмийн бувтнааныг сонссон юм шиг Фродо босоод явж одов. Түүний араас харахгүйн тулд нөхөд нь буруу харав. Гэвч Боромир түүнийг Овидын хажууд ургасан моддын цаагуур далд ортол араас нь ширтэхийг Сэм ажиглав.

Фродо ямар ч зорилгогүй алхаж байгаад нэгэн орхигдсон зам дээр гарч ирэв. Тэр зам уулын оргил өөд явсан байлаа. Замын дээш эгц өгссөн хэсэгт бараг эвдэрсэн чулуун гишгүүрүүд, олон газартаа бяцарсан модны үндэснүүд харагдаж байв. Фродо ямар ч бодолгүй дээш өгсөн гурван талаасаа уулын бөөрөлзгөнийн модоор хүрээлэгдсэн хонхорт ороод ирэв. Хонхрын тэг дунд том хавтгай саарал чулуу байх бөгөөд модод өглөөний нарыг халхлахгүйн тулд ухарч байгаа юм шиг Тол-Брандирын оргил болон түүн дээгүүр эргэлдэх шувуудыг ил гаргажээ. Алсад Рэрос сүртэйеэ хүрхэрнэ.

Фродо чулуун дээр суугаад, шанаагаа тулан гүн бодолд авгаж, нам жим болов. Бильбог Уутан хясаанаас явснаас хойших үйл явдлууд өмнүүр нь жирэлзэн өнгөрөх шиг санагдав. Тэр Гэндальфын яриа, аяны гараа, Элрондын болсон Зөвлөгөөн гээд бүгдийг санасан ч эцсийн шийдвэр гарч өгөхгүй, санаа хоёрдоод байлаа...

Гэнэт түүний дотор эвгүй болов. Хэн нэгний харц нуруу руу нь төөнөх шиг болж, санаа бодлыг нь таслан самууруулж байлаа. Тэр босон харайж, эргэн тойрноо хараад Боромирыг үзэж санаа нь амрав. Гондор баатрын нүүрэнд жаахан хүчилсэн мэт боловч сайхан сэтгэлийн

инээмсэглэл тодорч байв.

- Би чиний хойноос санаа зовоод, Фродо, хэрэв Арагорн үнэн хэлсэн, орхууд ойрхон байгаа бол ойд ганцаараа тэнэх аюултай. Ялангуяа чамд, чи дайснуудын хувьд хамгийн үнэтэй эрдэнэсийг авч яваа шүү дээ. Надад гашуун бодлууд төрөөд байна. Нэгэнт би чамайг олоод ирсэн юм, чи дэргэдээ суухыг зөвшөөрөөч. Бид бүгдээрээ хамтдаа байхад үг л хэлбэл маргалдаж эхэлдэг. Харин одоо энд хоёулхнаа байгаа болохоор ямар нэг мэргэн шийдвэр гаргаж чадах ч магадгүй шүү дээ.

- Баярлалаа чамд Боромир, - гэж Фродо хэлээд – тэгээд ч чи надад тусалж чадах болов уу даа. Яагаад гэвэл би юу яаж хийхээ мэдэж байна, гэхдээ айж байна. Зүгээр л айж байна, Боромир.

Фродо дуугүй болов. Рэросын нэгэн жигд хүржигнээн дундаас моддын нүцгэн мөчирт салхи исгэрэх сонсдоно. Боромир хоббитод дөхөж ирээд түүний дэргэд чулуун дээр суув.

- Чи дэмий юманд өөрийгөө зовоогоогүй гэдэгтээ итгэлтэй байна уу? – гэж тэр зөөлнөөр хариулаад – Бусдын тусламжаас татгалзах хэрэг юу байна? Чамд зөвлөгөө хэрэгтэй байгааг би харж байна. Намайг сонс, Фродо!

- Чи надад ямар зөвлөгөө өгөх гэж байгааг чинь мэдэж байгаад л хэргийн учир нь байгаа юм даа Боромир, - гэж Фродо өгүүлээд – тэр мэргэн зөвлөгөө шиг санагдаж байна... гэвч сэтгэл зүрх минь сэрэмжлүүлээд байна.

- Сэрэмжлүүлэх гэнэ ээ? Юунаас тэр вэ? – гэж Боромир огцом асуув.

- Хойшлуулахаас, хялбар зам хайхаас. Хүнд ачааг мөрөн дээрээсээ авч хаях хүслээс. Юу ч гэмээр юм бэ дээ...?.. Хүмүүсийн хүч чадал, итгэл найдварт сохроор итгэхээс.

- Гэвч тэр хүч чадал та нарыг үхлийн сүйрлээс найдвартай хамгаалж байгаа шүү дээ! – гэж Боромир дуу алдав.

- Би гондорчуудын баатарлаг гавьяанд өчүүхэн ч эргэлздэггүй. Гэвч ертөнц одоо хурдан өөрчлөгдөж байна. Минас-Тиритийн хана бат бэх гэж би мэднэ. Гэнэт тэр хана хангалттай бат бэх биш байвал яах вэ? Тэгвэл юу болох вэ?

- Бид үхлийг дайчны ёсоор угтана. Түүнээс гадна Дайсны цэрэг манай хана хэрмэнд шүдээ хугална гэсэн найдвар байна.

- Бөгж байгаа цагт тийм найдвар байхгүй.

- Бөгж гэнэ ээ! – гэж Боромир түүний үгийг шүүрч авахад нүд нь гялалзаж байв: - Алтан бөгж мэтийн тийм өчүүхэн шал дэмий юм бид бүгдэд ийм их төвөг тарьж байгаа нь хачирхалтай биш гэж үү. Тэрнийгээ надад үзүүлээч, Элрондын зөвлөл дээр би тэр рүү хараа ч үгүй, ядаж ямаршуу юм байдгийг нь харъя.

Фродо нүдээ өргөн Боромир рүү хараад нүд нь хачин гялалзаж байхыг үзэв. Гондор баатрын царай урьдын адил нөхөрсөг харагдаж байсан ч хоббитод нэг л хачин хүйтэн хөндий

мэдрэмж төрөв.

- Тэрнийг ил гаргахгүй байсан нь дээр – гэж Фродо товчхон хариулав.

- Тийм бол тийм л биз, чиний мэдэх хэрэг – гэж Боромир шууд ухраад – гэвч тэрний тухай ярьж болно биз дээ? Та нар тэрнийг Дайсан гартаа оруулчихвал аймшигтай их хүчтэй болох тухай байнга ярьдаг. Ертөнц өөрчлөгдөж байна, хэрэв бөгжийг устгахгүй бол Минас-Тирит, дараа нь Дундад газар тэр чигээрээ Харанхуйн хөшгөн доор сөнөнө гээд л. Тэгж ч магадгүй, би үүнтэй маргахгүй. Тэгвэл бөгж бидний гарт үлдвэл юу болох вэ?

- Бөгж зөвхөн хар муу үйлэнд л тусална гэж Элронд зөвлөл дээр бидэнд анхааруулсан шүү дээ.

- За чи бусдын хоолойгоор бүү дуул! – гэж Боромир хашгирав. Тэр босч хонхор дундуур тайван бус нааш цааш алхаж эхлэв: - Тэдний зөв ч байж болно: Гэндальф, Элронд, бусад бүх мэргэд, шидтэн, эльфүүд зөвхөн өөртөө л зөв ч байж болох юм. Магадгүй тэдний гарт бөгж орчихвол тэд хар муу үйлтнүүд болчихож мэдэх л юм. Гэхдээ тэд үнэхээр мэргэн ухаантан юм уу, зүгээр л аймхайчууд юм уу, би одоо болтол мэдэхгүй л байна... Гэвч биднийг – энэ олон жил Дундад газрыг Хар эзнээс хамгаалж байгаа Минас-Тиритийн хүмүүсийг хар муу үйлтэн болгон хувиргаж чадахгүй! Бидэнд ертөнцийг эзэгнэх юм уу, Дайсны ид шидийг эзэмших хэрэгцээ байхгүй. Бид өөрсдийнхөө эрх чөлөөг хамгаалахын төлөө бүх нийтийн дайсныг бут ниргэхийг л хүсч байна. Тэгээд л гүйцээ. Гэтэл бүх юм тун хачин давхцаж байгаа биз. Бидний хүч барагдаж байгаа энэ үед бүгдийг захирагч агуу бөгж дахиад гараад ирдэг – хувь заяаны бэлэг гэхээс өөр юу гэх билээ! Ялалтад зөвхөн шийдвэр төгс байдал, аймшиггүй чин зориг л хүргэдэг. Шударга тулалдаанд ялахын тулд эрэлхэг дайчин юунд ч бэлэн байх хэрэгтэй. Жинхэнэ дайчин ялалтын төлөө юу эсийг хийдэг билээ? Арагорн юу эсийг хийх вэ? Хэрэв тэр татгалзвал Боромир тулалдаанд цочно гэж үү? Бүгдийг захирагч бөгж надад агуу их хүчийг өгнө. Миний тугийн дор бүх дундад газрын баатарлаг дайчид цугларна. Тэгээд бид Дайсны цэргийг үүрд үгүй болгоно!

Боромир Фродог мартсан юм шиг байв. Тэр хонхор дундуур нааш цааш сэтгэл хөөрөн алхалж, Минас-Тиритийг хамгаалах, сөрөг довтолгоон, хүмүүсийн хүчирхэг холбоо, ирээдүйн ялалтын тухай ярьсаар. Түүний дуу улам чангарч, Дайсныг ялах итгэл нь улам нэмэгдсээр байлаа. Бүр Дайсны цэрэг Мордор руу эмх замбараагүй зугтаж, дайсны үлдэгдлийг Хар цайзын дэргэд хайр найргүй бут ниргэн, Боромир агуу их, чин шударга, мэргэн хаан боллоо.

Гондор баатар гэнэт чулуун дээр толгой унжуулан сууж байгаа хоббитын өмнө зогсов:

- Тийм биш ээ, тэд бөгжнөөс салахыг л хүсч байна! – гэж тэр хашгираад – Яг үнэндээ бөгжийг устгах биш, түүнээс салахыг л хичээж байна, тэгээгүй сэн бол өчүүхэн одой хүн харанхуй Мордор руу сохроор шургахгүй байсан, хэрэв шургах юм бол Дайсан тэр эрдэнэсээ гарцаагүй гартаа оруулна!

Боромир Фродогийн дээрээс харав.

- Чи өөрөө ч ойлгож байгаа биз дээ найз минь? – Чи айж байна гэсэн. Гэвч чиний дотор

айдас биш, саруул ухаан ярьж байна.

- Үгүй дээ, надад зүгээр л аймшигтай байна, Боромир. Гэлээ ч гэсэн чи санаагаа ил гаргаж хэлсэнд баярлалаа. Одоо надад эргэлзээ үлдсэнгүй.

- Аль эрт ингэх байсан юм! – гэж гондор баатар хэлэв.

- Чи намайг ойлгосонгүй, Боромир, - гэж Фродо хэлээд – Би Минас-Тирит явахгүй -гэв.

- Гэвч чи түр ч гэсэн манай нутгаар заавал орох хэрэгтэй. Минас-Тирит бүр ойрхон байна. Чи Хясаатаас Мордор хүртэл манай нутаг хүрэхээс яасан ч хурдан хүрэхгүй. Манайд очоод чи Дайсны талаар сүүлийн үеийн мэдээ сонсоно. Явцгаая, Фродо – гээд Боромир түүний мөрөн дээр нөхөрсгөөр гараа тавилаа. Гэвч гондор баатрын сэтгэл хөдлөлийг илэрхийлж, гар нь үл мэдэг чичирхийлж байв. Фродо босч, Боромир руу сандарсан байртай хараад арагш ухрав. Хүн хоббитоос хоёр дахин өндөр, хамаагүй хүчтэй билээ.

- Чи надаас айж байна гэж үү? Би урвагч юм уу, хар муу үйлтэнтэй адилхан байна гэж үү? Тиймээ, надад чиний бөгж хэрэгтэй байна, үүнийг чи одоо мэдэж байгаа. Гэвч би гондор дайчны нэрийг барин андгайлъя, ялалтын дараа би тэрнийг заавал өгнө. Шууд өгнө!

- Үгүй ээ! – гэж Фродо айсан дуугаар хэлээд: - Би түүнийг бусдад найдан хүлээлгэж чадахгүй. Би чадахгүй!

- Тэнэг! – Зөрүүд тэнэг! Чи тэнэгээсээ болж өөрөө ч үхнэ, биднийг ч сүйрүүлнэ. Хэрэв үхэлт амьтдаас хэн нэг нь агуу их бөгжийг эзэмшинэ гэвэл одойчууд та нар биш, нуменорын хүмүүн төрөлхтнүүд- зөвхөн тэд! Тэнэг тохиолдлоор бөгж чиний гарт орсон байна. Тэр минийх байж болох л байсан шүү дээ! Тэр минийх болох ёстой! Тэрнийг надад өг!

Фродо хариу хэлэлгүй ухрав. Үлэмж биет гондор баатраас ядаж чулуугаар ч гэсэн хамгаалах санаатай байв.

- Дэмий л айж байна даа чи, - гэж нэлээд тайвширсан Боромир хэлээд - чи бөгжнөөс салахад юу нь болохгүй байгаа юм бэ? Хамаг айдас, эргэлзээнээсээ ч сална шүү дээ. Тэгээд бөгжийг надаас хүчээр булааж авсан гээд зарлачих. Тэртэй тэргүй би чамаас хамаагүй хүчтэй шүү дээ, одой минь!.. гээд гондор баатар чулуун дээр үсрэн гараад Фродо руу дайрав. Түүний эрэлхэг, сайхан царай жигшмээр муухай болж, нүд нь шуналын галаар дүрэлзэв.

Фродо дахин чулууны цаагуур нуугдаж, чичирсэн гараараа бөгжөө гарган хуруундаа зүүв. Учир нь Боромир дахиад түүн рүү дайран орж иржээ. Мэл гайхсан гондор хоромхон зуурт нам зогссоноо алга болсон хоббитыг олохоор хонхор дундуур ийш тийш гүйж гарлаа.

- Новшийн хог! Чиний ухаанд юу байгааг би одоо мэдэж байна! Чи бөгжийг Сауронд өгөх гэж байна, тэгээд биднийг бүгдийг барьж өгөөд зугтаах далим хайж байна! Харж л байгаарай, чамайг би заавал барина! Гурав дахин хараал идээсэй чамайг. Дайсны орхидос, мөнхийн харанхуй, үхлийн мананд үүрд төөрөөрэй!.. – хэмээн галзуу мэт орилон гүйж байв. Тэр чулуунд бүдэрч унаад, өөрийнхөө хараалд хяргуулсан мэт хөдөлгөөнгүй хэвтсэнээ гэнэт

хөөрхийлөлтэй мэгшин уйлж эхлэв.

Салхи ширүүсч, салхины уйтгарт исгэрээн гондорын ухааныг сэргээв. Тэр удаанаар босч, нүдээ арчаад:

- Би юу хийчих нь энэ вэ? Яаж байгаа нь энэ вэ? Фродо! Фродо! – хэмээн айдас дүүрэн дуугаар хашгираад - Фродо, буцаад ир! Миний ухаан булингартжээ, гэвч одоо зүгээр болсон! Фродо!..

Гэвч Фродо аль хэдийн холджээ. Юу ч сонсолгүй, Боромирын хашгирааныг ч сонсолгүй, замаа ч харалгүй тэр дээш гүйж байв. Өрөвдөх, айх хоёр мань хоббитын зүрхийг шимшрүүлж байв.

Тэр уулын орой дээр гараад амьсгаагаа дарж, эргэн тойрноо харав. Түүний нүдэнд манан дундаас тодорч байгаа юм шиг чулуун хавтангаар зассан дугариг талбай, түүнийг тойрсон чулуун хашаа, дөрвөн баганатай сүүдрэвч болон сүүдрэвчид орох олон гишгүүртэй шат үзэгдэв. Энэ бол Амон-Ведар буюу нийтийн хэлээр Овид хэмээх нуменорчуудын харуулын аварга цамхаг байна гэж хоббит ойлголоо. Тэр шатаар дээш гараад, сүүдрэвчид орж, харуулын суудалд суугаад эргэн тойрныг харав.

Гэвч эхлээд манантсан сүүдрүүдээс өөр юу ч харсангүй. Учир нь түүний хуруунд Дайсны бөгж зүүлттэй байлаа. Дараа нь сүүдрүүд гэнэт өөр өөрийн өнгө төрхөө олж, мань хоббит шувуу шиг тэнгэрт дүүлж байгаа адилаар асар уудам газрыг харж эхлэв. Дорно зүг рүү үл мэдэх тал цэлийж, түүний цаана үл мэдэх уулс сүндэрлэж байна. Хойт зүгт Андуин мөрөн туузран гялалзаж, зүүн талд Андуин мөрөн рүү Манант уул цаст оргилуудаа цахилуулан ойртжээ. Баруун талд Ристанийн бэлчээр ногоорон, Гэндальфыг Салхин жигүүр авч явсан Ортханкийн цамхаг цэгийн төдий харлаж харагдана. Өмнө зүгт Болоний намагт тал руу уруудаж буй Хясаат гол хөөсрөн, Андуин Этэрийн тал руу ороод олон салаалан мөнгөлөг саарал Тэнгис рүү орж байна. Тэнгисийн дээгүүр нарны тоос мэт тоо томшгүй олон шувууд хуйларна.

Гэвч цэцэглэж буй Дундад газарт энх амгалан биш байлаа. Манант уулсад орхууд шоргоолж адил бужигнаж байв. Дорнод Балар шугуйн цэнхэр нарснуудын доор хүмүүс, эльфүүд, араатнууд алалдан байлдаж байна. Лориэний хил хязгаарт утаа суунаглаж байна. Морийн дээгүүр хар үүл бүрхжээ. Брандийн газарт түймэр дүрэлзэж байна.

Зэвсэглэсэн морьтнууд Ристанийн уудам талаар давхилдана. Изенгардыг чонодолоохын сүргүүд хамгаалж байна. Дайсны тоо томшгүй есөн жорын сүргээс бүрдсэн хүчирхэг арми баруун зүг рүү цувж байна.

Фродо өмнө зүг рүү дахин харав. Андуинаас баруун тийш, Цагаан ууланд гондорчуудын найдвар болсон халдахын аргагүй цагаан хэрмээр хүрээлүүлсэн Минас- Тиритийн хүчирхэг цайз бардмаар сүндэрлэн байна. Хоббитын зүрхэнд найдварын оч улалзав. Гэвч Андуинаас дорно зүгт, Изгарын уулсын дэргэдэх хар өндөрлөг дээр асар олон амьтан язганасан, аймшигтай сүрлэг, асар том хар цайз босчээ. Изгарын уулсын цаана, Горгоратын хөндийд хүрэн улаан утаагаар бүрхэгдсэн Галт уул ганцаараа хурц наран дор ч харанхуйлан сүмбэрлэж

байна. Хоббитын харц түүнээс цаашлав. Фродо харахаа болих гэсэн ч чадсангүй. Үй олон хана хэрэм, харуулын цамхаг, хар аалз мэт Барад-Дур буюу Сауроны ичээ болсон Харанхуй цайз харагдав. Харанхуй хоббитын найдварыг унтраалаа. Дараа нь тэр НҮД-ийг мэдрэв.

Нүд түүний бөгжийг зүүсэн хадгалагчийг хичээнгүйлэн хайж байлаа. Тэр нүд Дундад газрыг нэгд нэггүй тэмтрэн шалгаж байна. Нүднээс нуугдах боломжгүй болохыг Фродо ойлгов. Тэр нүд бас чихтэй ажээ. Одоо тэр Хясаат уулын хавцлаар тэмтэрч байна.... Фродо харуулын суудлаас үсрэн буух гээд халтиран унаж, өвдсөндөө эвхрэн, лориэний юүдэнгээр нүдээ хаав.

Тэрбээр: Өгөхгүй! Бууж өгөхгүй! -хэмээн дотроо шивнэж байсан ч сүүдрэвчид: Өгнө! Бууж өгнө! – гэсэн цуурай хадаж байв. Дараа нь түүний толгойд: Тайлаач! Хар тэнэг ээ, тайлаач бөгж өө! – гэсэн дуу хадаад Овидын дээгүүр нам гүм болов.

Өөдсөн чинээ хадгалагчид хоёр аварга их хүч тэмцэлдэж байв. Нэгэн хоромд тэр хоёр хүч тэнцэхэд мань хоббит ухаан алдав. Ухаан ороход нүд ч байсангүй, цуурай ч байсангүй. Тэр өөрийн чөлөөт ухаантай болмогц бөгжийг хуруунаасаа суга татав. Яг цагаа олжээ. Сүүдрэвч дээгүүр хар сүүдэр нисэн өнгөрөөд, доор булшны хүйт үлээх шиг болсноо дахин нар гэрэлтэж, тэнгэрт шувууд жиргэв.

Фродо хөл дээрээ удаанаар бослоо. Тэр өвчилсний дараах шиг бие суларсан байсан ч зүрх сэтгэл нь төгс хатуужсан байв.

- Би ганцаараа явах ёстой. Яагаад гэвэл бөгжний харанхуй хүч манай отрядад ч үйлчилж байна. Тийм ээ, би ганцаараа явах ёстой. Одоо би бүгдэд итгэж болохгүй. Харин хэзээ ч надаас урвахгүй Сэм, Мерри, Пин нарт л итгэх хэрэгтэй. Гэвч би тэднийг Мордор руу дагуулж явна гэхэд дэндүү хайрлаж байна. Арагорн гондорчуудад туслахаар тэмүүлж байгаа, хэрэв Боромир халдвар авсан бол тэр одоо гондорчуудад хоёр дахин хэрэгтэй байгаа. Ганцаараа явах хэрэгтэй, яг одоо.

Тэр доошоо гүйж, хонхор руу ороод чагнатал түгшүүртэй хашгиралдаан сонсдов.

- Тэд намайг хайж байна – гэж тэр өөртөө хэлээд – хичнээн хугацаа өнгөрсөн нь сонин байна. Хэдэн цаг болсон байх.

Хашгиралдаан ойртож байх шиг санагдав. –Яах вэ? – гэж өөрөөсөө шивнэн асуулаа. Тэгээд: - Явах хэрэгтэй. Шууд. Тэгэхгүй бол хэзээ ч явж чадахгүй. Салах ёс хийж ч болохгүй. Тэд намайг ганцааранг нь явуулахгүй! Тэгэхлээр салах ёс хийлгүй явах ёстой.

Тэгээд Фродо бөгжийг зүүлээ.

Дөнгөж сая хоббитын зогсч байсан газарт гишгэгдсэн өвс л үлдэв. Доор, уулын хажуу бэлээр салхины исгэрээн мэт хөнгөн алхаа л сонсдоно.

Бусад хадгалагчид эрэг дээр тойрон сууж байлаа. Хэдийгээр хүн бүр тайван хүлээхийг хичээж байсан ч тэдний яриа байнга Фродогийн шийдвэр рүү орж байв.

- Түүнд үнэхээр хүнд сонголт тулгарч байна л даа. Орхуудаас болоод дорно зүгийн зам үхлийн аюултай, Гондор руу явахад бүр ч аюултай, учир нь бид хаана нуугдсаныг Дайсанд ховлоно, Хар хүчний түрэлтэд Минас-Тирит эрт орой хэзээ нэгэн цагт унана. Энэ цайз Дайсны бүх хүчний өмнө тэсэх боломжгүй гэж Элронд хүртэл сануулж байсан шүү дээ. Яах вэ? Зөвхөн Гэндальф л энэ аймшигт оньсогыг тааж чадах байсан болов уу гэж айж байна. Гэтэл Гэндальф байдаггүй...

- Тэгэхээр бид л таах хэрэгтэй боллоо. Бид Фродод туслах ёстой. Түүнийг дуудаад хаашаа явах талаар санал хураая. Дорно зүг зам хаалттай болохоор Гондор руу орж, байдлыг тандах хэрэгтэй гэж би бодож байна – гэж Леголас Арагорны өмнөөс хэлэв.

- Би ч бас тэгж бодож байна. Гэвч Фродо ямар ч гэсэн дорно зүг рүү эргэхээр шийдвэл би түүнтэй хамт явна – гэж Гимли хэлэв.

- Би ч бас явна, одоо түүнийг орхино гэдэг урвалт болно – гэж Леголас санал нийлэв.

- Бидний дотор урвагч байхгүй гэж бодож байна. Гэвч Фродо Мордор руу явахаар шийдвэл долоон хамгаалагч ч, далан долоон хамгаалагч ч тус болохгүй, харин ч гай болох байх... Том отрядыг илрүүлэх амархан. Тийм учраас би гурван хүнийг л санал болгож байна: Сэм /тэр эзнээ орхихгүй биз/, би, Гимли.

- Бид хоёр яах юм бэ? Пин бид хоёр бүр Норгордод байхдаа л Фродотой хаашаа ч хамаагүй явна гэж шийдсэн.... явах ч болно... Харин түүнийг шууд... Дайсны ам руу явуулах аймшигтай байна! Бид тэднийг зогсоох ёстой! – хэмээн Мерри уурлав.

- Мэдээж, зогсоох ёстой! – гэж Пин найзаа дэмжээд: - Одоо тийшээ явна гэж санаанд багтах зүйл биш! Одоо тэр шийдэж чадахгүй байгаа нь: бид түүнийг ганцааранг нь явуулахгүй, тэр өөрөө биднийг хамт явъя гэж гуйж чадахгүйгээ ойлгож байгаа юм.... хэрэв бид түүнийг хориглож дийлэхгүй бол ямар ч гуйлтгүйгээр өөрсдөө явж болох юм.

- Та нар ч манай эзнийг мэдэхгүй байна даа, - гэж Сэм ярианд оролцоод – Тэр шийдэж чадахгүй байна гэж үү? Бүр Лориэнд байхдаа шийдвэрээ гаргасан юм шүү! Тэр Минас-Тирит түүнд ямар хэрэгтэй юм бэ? Чи битгий уурлаарай – гээд гондор баатрыг нүдээрээ хайснаа – ингэхэд Боромир хаачив? - Тэр өчигдрөөс хойш нэг л хачин байсан.... За тэр ч яахав, орон гэр нь ойрхон байгаа, биднийг бодохтой манатай байгаа биз... Харин эзэн маань Мордор руу явна гэж аль эрт шийдсэн юм шүү. Шийдсэн мөртөө айгаад байсан юм. Одоо ч гэсэн түүнд аймшигтай байгаа. Тэр Хоббитанаас гарснаас хойш зөндөө л юм үзсэн, гэсэн ч тэр хараалт бөгжийг нэг гол руу шидчихээд харсан зүг рүүгээ зугтаагүй.... Гэлээ ч гэсэн айдас түүнийг хүлээд байна. Ер нь энд айгаагүй хүн хэн байгаа юм бэ? Тэр биднийг сайн ойлгож байгаа, хэн нь ч хаяад явахгүй гэдгийг мэдэж байгаа, энэ л түүний гол саад байгаа юм. Тиймээс ганцаараа явахаар шийдсэн. Тэр одоо хүрээд ирнэ, тэгэхлээр бид нэлээн зовно доо. Миний үгийг тогтоож ав. Тэр хэнийг ч Мордор руу авч явахыг хүсэхгүй!

- Сэмийн зөв байх аа, тэгэхлээр одоо бид яах вэ? – гэж Арагорн асуув.

- Түүнийг явуулахгүй! Яасан ч явуулж болохгүй! – гэж Пин хашгирав.

- Бидэнд ийм эрх байхгүй, тэр бол бөгжний гол хадгалагч, тэгэхээр тэр бөгжний хувь заяа ганцаараа хариуцна. Бид түүнд дур зоргоо тулган хүлээлгэж болохгүй. Болох ч үгүй, чадах ч үгүй. Агуу их бөгжний төлөө тэмцэлд хэтэрхий аймшигт хүчнүүд татагдан ороод байна – гэж Арагорн өгүүлэв.

- Тэгвэл түргэн хүрээд ирэг, юу л болбол болог, ингэж удаан хүлээвэл галзуурч мэдэх юм байна. Нэг цаг аль хэдийн өнгөрөө биз дээ?

- Цаг ч аль хэдийн өнгөрсөөн, одоо ирмээр л юм даа.

Хадгалагчид босч байтал моддын цаанаас сандарч, баргар царайлсан Боромир гараад ирэв. Тэр нөхдөө тоолон бүртгэж байгаа аястай зогслоо. Тэгснээ тэднээс зайдуухан өвсөн дээр суучихав.

- Чи хаачаад ирэв, Боромир? - Фродо тааралдсангүй юу? – гэж Арагорн асуухад:

- Тааралдсаан, тэгээд алга болчихсон. Би түүнийг Минас-Тирит явья гэж ятгасан... тэгээд би жаахан уурласан... тэгээд тэр алга болсон. Бодвол бөгжөө зүүсэн биз. Газрын гаваар орсон юм шиг л алга болсон. Би хайгаад олсонгүй. Хүрээд ирсэн юм байх гэж бодлоо.

- Чамд өөр хэлэх юм байхгүй юу? – гэж Арагорн гондор баатраас хөмсөг зангидан асуув.

- Одоохондоо юу ч алга – гэж Боромир нэлээд хүчлэн байж хариулав.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? – гэж Сэм айсан дуугаар хэлээд – Тэрнийг зүүж болохгүй шүү дээ! Тэрнээс болж ямар их гай зовлон тохиолдохыг ганцхан Дайсан л мэдэх байх!

- Тэр дор нь тайлсан байх л даа, Бильбо урилгагүй зочдоос салахыг хүсэхдээ зүүсэн шиг – гэж Мерри хэлэв.

- Хаашаа явчихав аа? – Ирэхгүй хичнээн удав! Одоо хаана байна? – гэж Пин хашгирлаа.

- Чи түүнийг хэзээ харсан бэ, Боромир? – гэж Арагорн асуув.

- Хагас цагийн өмнө... цагийн өмнө ч байж магадгүй – гэж гондор итгэлгүйхэн хариулаад: - Тэр алга болчихсон... Би нэлээд удаан хайсан. Би мэдэхгүй! Мэдэхгүй!.. - гээд Боромир толгойгоо барин дуугүй болов.

- Бүтэн цаг уу? – гэж Сэм дуу алдсанаа: - Хурдлаарай! Явцгаая! Түүнийг олох хэрэгтэй! – гээд ой руу ухасхийлээ.

- Хүлээж бай! – гэж Арагорн түүнийг зогсоогоод: - Ганцаараа явж болохгүй! Хоёр хоёроороо явья!..

Хэн ч түүний үгийг сонссонгүй. Сэм ой руу гүйгээд орчихлоо. Мерри, Пин хоёр Мөрний эргээр гүйлээ. Тэд: “Фродо! Фродо!” – хэмээн хашгирч, тэдний чанга дууг хадан уулсын цуурай алс холд тарааж байв. Леголас, Гимли хоёр ч ой руу орлоо.

Арагорн Сэмийн араас ухасхийснээ зогсоод Боромирт:

- Ухаан ор! Чи Фродог яасныг одоо мэдэх цаг алга. Пин, Мерри хоёрын араас гүй. Тэр хоёрыг хамгаал, хэрэв Фродо олдохгүй бол эндээ хүрээд ир. Би ч удахгүй хүрээд ирнэ.

Боромир Мөрний дагуу гүйлээ. Арагорн уул өөд өгсөв. Тэр Сэмийг гурван талаасаа бөөрөлзгөнийн модоор хүрээлэгдсэн хонхорт гүйцэж авлаа. Хоббит амьсгаадан Фродо тэнд нисээд хүрчихсэн юм шиг Тол-Брандир руу харж байв.

- Хамтдаа явъя, бидний хэн ч энд ганцаараа тэнэж болохгүй. Ямар ч гай гараад ирэх юм бүү мэд. Би мэдрээд байна. Хурдал! Хоёулаа Амон-Ведарын эргэн тойронд юу болж байгааг харъя. Миний бодлоор Фродо тийшээ л явсан. Надаас битгий хоцор, ийш тийшээ сайн харж яв – гээд Арагорн Харуулын цамхаг өөд хурдан хурдан алхлав.

Сэм түүний алхааг гүйцсэнгүй, барааг нь алдаад түр зогслоо.

- Хөлөөрөө ажиллаж чадахгүй юм бол толгойгоороо ажилла. Гондор хүн худлаа хэлдэггүй. Харин бүгдийг нь ярьсангүй дэг ээ. Ямар нэг шинэ юм эзнийг айлгасан, тэгээд л гэнэт зугтахаар шийдэж. Хаашаа? Мэдээж зүүн зүг. Сэмгүйгээр явчихдаг байна шүү. Хоббитын нүд нулимсаар дүүрч эхэлснээ: - Чи битгий енгэнээд бай, харин бод! – гээд өөрийгөө цохиж авснаа: - Эзэн одоохондоо нисч чадахгүй. Зүүн зүг рүү Мөрнөөр явна. Эрэг дээр завь байгаа. За Сэм минь, хөлийнхөө хурдаар эрэг рүү, тэнд амжиж гүйцнэ!

Хоббит буцаж доош хурдаллаа. Өнхөрч унаад өвдгөө цус гартал шалбалж, ухасхийн босоод цааш хурдав. Эрэг дээр ирлээ. Сэм сайтар харав. Тэгснээ нам зогсоод нүдээ бүлтийтэл гайхав. Эргээс нэг завь аажуухан холдож байна. Хоосон завь. Дэргэд нь юу ч харагдсангүй. Хоббит нэг хашгирснаа Мөрөн рүү ухасхийв. Хоосон завь ус руу орлоо.

- Би ч бас! – Би ч бас хэмээн – Сэм хашгираад Андуин мөрөн рүү үсрэв. Завь эргээс холдлоо. Сэмийг хүчит урсгал хаман авч, тэр дорхноо үзэгдэхгүй болов.

Хоосон завинаас чангаар хараах сонсдож, сэлүүр нь түргэн түргэн ажиллан, завь Сэмийн алга болсон газарт ирэв.

Сэмийн толгой усан доор байв. Түүний бүлтийсэн нүдэнд айдас тогтжээ. Тэр хахаж цацан ус тургилж, Фродоо түүн рүү зүүн гараа сунгаж, баруун гараараа үснээс нь базаж авав.

- Зүгээр зүгээр, миний гараас барь, одоо эрэгт очлоо – гэж айдас дүүрэн хэлэв.

- Авраарай! Би гарыг чинь харахгүй байна! Живлээ! Авраарай - гэж Сэм өрөвдөлтэй хашгирав.

- Энэ байна, энэ! – гээд Фродо Сэмийн мөр рүү цохиход цаадах нь гараас нь зуураад авлаа.

- Завины ирмэгээс барь, би сэлүүрдэх хэрэгтэй – гэж Фродо хэлэхэд Сэм завинаас зуураад авлаа.

Фродо хурдан сэлүүрдэж эрэгт хүрээд, завнаас бууж, бөгжөө тайлав. Сэм нуга дээр яаран гарлаа.

- Та яахаараа ингэж шийддэг байна аа? – гэж Сэм дагжин чичирч: - Би амжаагүй бол та яах байсан бэ?

- Зүүн зүг тайван хөвөх байлаа – гээд Фродо өөрийн эрхгүй инээмсэглэв.

- Тайван гэнэ шүү! – Бүгдийг нь орхиод, тэр ч байтугай намайг орхиод уу? Ямар нэг юм тохиолдвол яах вэ? Хэн танд туслах юм бэ? Ганцаараа шүү ! Тэгэх юм бол би тэвчиж чадна гэж үү!

- Чадахгүй юу? Замдаа амь үрэгдвэл яах юм бэ? Тэгвэл би тэвчиж чадах уу? Би Мордор руу явж байгаа шүү дээ!

- Өөр хаашаа явах юм бэ? Мэдээж Мордор руу, хамт явна аа...

- Сонсч бай Сэм, одоо нөхөд маань эргэж ирээд төгсгөлгүй маргаан болно. Би заавал явах хэрэгтэй. Үүнд л цорын ганц аврал байна, ойлгож үз!

- Ганцаараа явах бол үхэл болохоос аврал биш, би хамт явна. Эсвэл хоёулаа хаашаа ч явахгүй. Би таныг ганцааранг нь Мордор руу явуулахгүйн тулд бүх завины ёроолыг цоолно!

Фродо талархалтай бөгөөд хөгжилтэй инээж:

- Нэг завийг нь үлдээгээрэй, тэгэхгүй бол бид хоёр Андуиныг яаж гатлах юм бэ? За яахав, юм хумаа ав, хурдал!

- Би одоохон! – гэж Сэм баяртайяа дуу алдаад: - Юмаа бэлдчихсэн, харин жаахан идэх юм л аваадахья...

Фродо эргээс хөдлөхдөө:

- За ингээд ганцаараа явж чадсангүй. Үнэнээ хэлэхэд чадаагүйдээ баярлаж байна шүү. Маш их баярлалаа, хайрт Сэм минь! Бид хоёр эцсээ хүртэл хамт явах заяатай юм байлгүй дээ. Нөхөд маань аюулгүй зам олно гэж найдъя. Бид хоёр тэдэнтэйгээ хэзээ нэгэн цагт уулзах болов уу даа.

- Уул уултайгаа уулздаггүй гэдэг биз дээ, бид чинь уул биш шүү дээ.

Хоёр хоббит зүүн зүг хөвлөө.

Фродо хичээнгүйлэн сэлж байсан ч урсгал хөнгөн завийг дураар нь явуулахгүй байв. Хясаат уул ард хоцорч, Хясаат хүрхрээний чимээ улам ойртсоор байлаа. Сэм эзэндээ чадлын хэрээр тусалж, хоёр хоббит агуу хүчирхэг Андуиныг удаан ч гэсэн гаталж чадав.

Эцсийн эцэст тэр хоёр Сонорчих уулын өмнөд бэлд хүрэв. Завинаасаа шуудайтай юмаа аваад

уснаас холдуулж, том саарал бул хадны ард нуув. Тэгээд алгуурлалгүй замдаа гарлаа.

ХОЁРДУГААР ДЭВТЭР

Бүлэг 1

Боромир

Арагорн газар шагайн эгц зөргөөр өгсөн гүйлээ. Хоббитууд их хөнгөн гишгэдэг, мөрч хүртэл тэдний мөрийг алддаг удаатай билээ. Гэвч оргилын орчимд зөргийг горхи норгосон учир дөнгөж үзэгдэх төдий мөр олдлоо.

“Зөв байна, Фродо дээш гарсан байна. Тэр тэнд юу нээсэн юм бол? Өө, энэ буцсан мөр нь байна”.

Тэр хэсэг тээнэгэлзэв. Харуулын байран дээр гарвал ямар вэ? Тэндээс хаашаа явах маань тодорхой болох юм биш биз дээ? Гол нь хурдлах хэрэгтэй... Арагорн гэнэтхэн шийдээд том том хавтан замаар дээш гүйн, хөвд ургасан гишгүүрүүд дээгүүр нь харайн дүүлсээр Харуулын байранд орж, харуулын суудал дээр суугаад эргэн тойрныг хараачлав.

Гэвч нар бүүдийж, тэнгэрийн хаяа улам цайран цаашлах шиг болов. Арагорн умар зүг рүү тэмүүлэв. Тэнд дүнсгэр оргилуудын дээгүүр аварга том бүргэд өргөн эргэлтээр доошилж байв.

Тийнхүү харж байснаа гэнэт намсхийн чагнав. Түүний сонор чих Андуины эрэг дээрх бэлийн ойд ямар нэг шуугиан болж байгааг бүдэгхэн сонсов. Хашгиралдах чимээ сонсоод тэр улам ч болгоомжлов. Орхууд байдаг хоолойгоороо бархиралдаж байлаа. Дараа нь эвэр бүрээ хүнгэнэн цуурайлж, бардам яруу дуу нь уул хадыг нүргэлүүлэн хүрхрээний нүсэр чанга чимээг дарав.

- Боромирын бүрээ байна! – хэмээн тэр уулгамчлав. - Боромир, Боромир тусламж дуудаж байна!

Тэрбээр гуравхан харайгаад шатны гишгүүрүүдийг дуусгаж, зөргөөр хурдаллаа.

- Гай газар дороос гардаг өдөр байна даа, хийсэн бүхэн минь бүтэлгүйтээд байдаг, ядаж Сэм хаачдаг байна аа - хэмээн тэр гүйж явах зуураа үглэв.

Арагорн байдаг хурдаараа жирийж, орхуудын орилоон улам чангаран, бүрээн дуу эцсийн хүчээ шавхаж байх мэт, улам улам суларсаар... орхуудын орилоон баяр бахдлаар дүүрч, эвэр бүрээний эр хонгор дуудлага тасарлаа. Уулын яг бэлд хүрэх үест орхуудын орилоон ч тасрав. Тэр зэвүүн орилооны чимээ намжиж, зүүн тийш холдсон тул Арагорн тэр зүг рүү эргэв. Эргэн тойронд нам гүм болоход тэр илдээ сугалаад, “Элендил! Элендил!” – хэмээн тулааны уриагаа хашгираад шугуй дундуур хурдлав.

Парт-Гален буюу эльфээр Ногоон нугад, ойн бяцхан чөлөөнд Боромир байж байв. Тэр зүгээр л түр амарч байгаа юм шиг, нэгэн аварга хүчирхэг мод түшин сууж байлаа. Гэвч түүний бүх биед хар өдөт сумнууд шивж, баруун гарт нь бариулаараа хугарсан илд атгаастай, дэргэд нь хоёр хэсэг болон задарсан эвэр бүрээ нь хэвтэж байна. Түүнийг тойрон тасар тасар

цавчуулсан дайснуудын хүүр хөглөрчээ.

Арагорн түүний өмнө өвдөг сөхрөн суухад Боромир нүдээ нээж ярих гэж байдаг хүчээ шавхав. Тэгээд.

- Би Фродогоос бөгжийг авах гэж оролдсон юм. Би буруутай. Гэхдээ би төлөөсөө төлчихлөө - гэв.

Тэрбээр дайснуудын хүүрийг нүдээрээ тоолов. Дөчөөд юм байлаа.

- Жижгүүдийг... би аварч хүч хүрсэнгүй. Гэхдээ тэднийг алаагүй..., хүлээд л... - гээд тэр нүдээ аньж. - Хагацъя даа, Арагорн минь! Минас-Тирит явж манайхныг авраарай, харин би... би ялагдлаа.

- Үгүй ээ! - гэж Арагорн хашгираад, түүний гарыг атгаж, хөрч байгаа духан дээр нь үнсээд.

- Чи ялсан. Чиний ялалт агуу их. Амгалан нойрсоорой! Минас-Тирит тэснэ ээ. Би түүнийг аварна! гэхэд Боромир үхлийг эцсийн удаа ялан баяртайяа инээмсэглэв.

- Хаашаа? Хаашаа явахыг нь харсан уу? Фродо тэдэнтэй хамт байсан уу? – гэж Арагорн түүний уруулд чихээ наан хашгирсан боловч Боромир үүрд дуугүй боллоо.

- Ээ чааваас даа! – гэж Арагорн гаслан уйлж. - Харуулын хэрмийн захирагч Денэторын удам ингээд өвөг дээдэс рүүгээ явчихдаг байжээ! Миний буруугаар бүлэг маань тарчихлаа. Гэндальф надад найдах хэрэггүй л байж дээ. Одоо би яах вэ? Боромир амьсгаа хураахынхаа өмнө намайг Минас-Тирит рүү яв гэж тушаасан, зүрх сэтгэл минь ч тийш нь дуудаж байна. Гэвч бөгж, хадгалагч хоёр хаана байна? Би яаж тэднийг олох вэ, яаж тэр агуу их үйлийг бүтээх вэ?

Арагорн өвдөг сөхрөн сууж, Боромирын амьгүй болсон гар дээр нулимсаа дуслуулан халаглаж байтал Леголас, Гимли хоёр ирэв. Гимли цусанд будагдсан сүхээ барьж, Леголас бас л улаан өнгөтэй болсон урт кинжал барьжээ. Түүний сум нь дууссан байв. Тэр хоёр ойн чөлөөнд гарч ирээд энд юу болоод өнгөрснийг ойлгож, балмагдаж гайхсандаа тэргүүнээ гудайн нам зогсов.

- Ээ чааваас! Бид хоёр орхуудыг хөөгөөд ойд оруулж хядсан, гэтэл байх ёстой газар маань энэ байж, бид хоёр Боромирын бүрэн дууг сонсонгуут наашаа гүйсэн ч хожимдчихлоо - гэж Леголас Арагорнтай зэрэгцэн зогсоод халаглав.

- Тийм ээ, Боромир байхгүй боллоо, харин би... - гэж - Арагорн бүдэгхэн өгүүлээд –амьд мэнд, бүрэн бүтэн байна, энэ маань хоббитуудыг хамгаалж байгаад алагджээ. Би энд байгаагүй, уулын орой дээр байсан юм.

- Хоббитуудыг гэнэ ээ? – гэж Гимли дуу алдаж. - тэд нар хаана байна? Фродо яасан бэ?

- Мэдэхгүй ээ, - хэмээн Арагорн ядрангуй хэлээд. - Боромир амьсгаа хураахдаа тэднийг орхууд хүлсэн, алаагүй гэж хэлсэн. Би Боромирыг Мерри, Пин хоёрыг хамгаал гэж явуулсан

юм. Фродо, Сэм хоёр хаашаа явсныг би мэдэхгүй, Боромироос асуухад нэгэнт оройтсон байсан. Өнөөдөр миний хийсэн бүхэн буруугаар эргээд байна. Одоо яах вэ?

- Алагдсан баатрыг оршуулна. Түүнийг энэ үхдлүүдийн сэгэн дунд орхилтой биш! – гэж Леголас хэлэв.

- Харин аль болохоор түргэхэн хөдөлье. Тэр өөрөө амьд байсан бол бас л ингэж хэлэх байсан. Баригдсан хоббитууд амьд байж магадгүй гэсэн горьдлого байгаа дээр орхуудыг гүйцэх хэрэгтэй – гэж Гимли яарав.

- Бөгж хадгалагч тэдэнтэй хамт байгаа эсэхийг бид мэдэхгүй шүү дээ. Тэр байхгүй бол яахав? Хамгийн түрүүнд түүнийг хайх хэрэгтэй! Тийм ээ, бид хүндхэн сонголттой тулгарлаа!

- За тэгвэл хойшлуулшгүй чухлаас нь эхэлье. Бидэнд дайчин нөхрөө зохих ёсоор оршуулж, хиргисүүр босгох цаг алга. Чулуугаар бунханархуу юм хийдэг юм билүү - гэж Леголас санал болгоход.

- Бунхан хийхэд цаг их орно, чулууг голоос зөөж авчрах болно – гэж Гимли хэлэв.

- Тэгвэл сал хөвүүлэхээс, өөрийнх нь зэвсгийг алсан дайснуудынх нь зэвсэгтэй хамт хөвүүлье. Түүнийхээ шарилыг Рэросын хүрхрээ, Андуины урсгал хоёрт даатгая. Гондорын их мөрөн Гондор баатар вангийн цогцсыг бузар буртгаас хамгаална – гэж Арагорн өгүүлэв.

Тэр гурав орхуудын зэвсгийг цуглуулав.

- Энийг хараач! – гэж Арагорн гэнэт дуу алдав.

- Энэ нэг юм хэлж байгаа юм биш үү? - гээд Арагорн овоолоостой зэвсэг дотроос алтан шигтгээтэй гялалзсан хоёр илд, жижигхэн бадмаараг эрдэнийн шигтгээ цацсан хоёр хар хутга гаргаж ирэв.

- Орхуудад ийм зэвсэг байдаггүй, тэд манайхныг нэгжээд зэвсгийг нь авч зүрхэлсэнгүй. Энэ бол тэдэнд аюултай зэвсэг. Яагаад гэвэл өрнөд хязгаарын уран дархчууд Мордорыг хараасан рун бичээс хийж давтсан юм. Тэгэхлээр найзууд маань зэвсэггүй байгаа бол амьд байна гэсэн үг. Энэ зэвсгүүдийг авч явна аа, эд эзэндээ элдэв аюулыг арилган эргэж очиж магадгүй – гэж тэр хэлэв.

- Харин би бүтэн сум байвал хэнийх ч байсан хамаагүй авна, саадаг минь хоосон байна – гэж Леголас хэлээд эргэн тойрныг нэгжиж арваад бүтэн сум олов. Тэр сумнууд орхуудын ердийн сумнуудаас урт байлаа. Леголас тэдгээрийг бодлогошрон харж зогсов.

Тэр хооронд Арагорн алагдагсдыг ажиглаад.

- Эдний олонхи нь Мордороос ирээгүй байна. Би тэднийг мэдэлгүй яахав, Манант уулаас ирсэн умардын орхууд ч байна. Хаанаас ирснийг нь ч бүү мэд гэмээр орхууд ч байна. Зэвсэг нь ч гэсэн ондоо юм - гэлээ.

Үхдлүүдийн дунд дөрвөн асар том гоблин хэвтэж байх бөгөөд хар царайтай, хялар нүдтэй, лужир том гар хөлтэй тэдний зэвсэг нь богино өргөн илд, хүнд л таарахаар урт махир нум байв. Тэдний бамбай дээр үл мэдэгдэх тэмдэг байсан нь хар талбай дээрх жижигхэн цагаан даль бөгөөд дээр нь руны С үсэг байв.

- Би урьд өмнө ийм юм харж байгаагүй юм байна, ямар утгатай юм бол доо - гэж Арагорн гайхав.

- С үсэг бол “Саурон” гэсэн үг, тааж ядаад байх юм алга – гэж Гимли хэлэв.

- Үгүй дээ! - хэмээн Леголас толгой сэгсрээд - Саурон гэдэг үгийг эльфийн рун бичгээр бичнэ гэж үү?

- Сауроны жинхэнэ нэр хориотой, тэрнийг бичиж ч болохгүй, дуудаж ч болохгүй - гэж Арагорн хэлээд. - Цагаан өнгөнд тэр яснаасаа дургүй. Үгүй ээ, Барад-Дурын орхууд галт нүдэн тэмдэгтэй байдаг – гээд түр бодолхийлснээ - С үсэг бол “Саруман” гэсэн үг байна. Изенгардад хар муу үйл шүглэсэн, одоо гэнэн итгэмтгий өрнөдийнхөнд гай зовлон ирнэ. Энэнээс л Гэндалф эмээгээд байсан юм. Урвагч Саруман манай аяны талаар яаж ийгээд мэдсэн байна. Гэндалф үгүй болсныг ч мэдсэн байна. Лориэний эльфүүд Мориин бүх цэргийг хиар цохиогүй, тэгээд ч Изенгардад тойруу зам бий. Орхууд саатаж алгуурлаж сураагүй. Саруманд тэднээс өөр тагнуулчид ч бий. Нөгөө шувуунуудыг санаж байна уу?

- Энд олон оньсого байна, харин таах цаг алга – хэмээн Гимли түүний үгийг таслаад. - Боромирт сүүлчийн хүндэтгэл үзүүлцгээе! – гэв.

- Гэлээ ч гэсэн зөв сонголт хийхийн тулд оньсого таах л болж байна даа - гэж Арагорн хариулав.

- Хичнээн ч сонголоо гэсэн тэртэй тэргүй буруу сонгоно – гэж гном баатар хэлэв.

Тэгээд Гимли байлдааны сүхээрээ бүдүүн мөчир цавчиж, мөчрүүдийг нумаар холбоод дээр нь цувнууд дэвслээ. Тэрэн дээрээ даяин баатрынхаа шарилыг тавьж, түүний сүүлчийн гавьяаны чимээгүй гэрч болсон зэвсгүүдийг овоолов. Гол хүртэл ойрхон зай байсан ч талийгаач баатар вангийн шарил нэн хүнд байсан тул энэ ойрхон зайг тэд багагүй зүдэрч тууллаа.

Арагорн эрэг дээр үлдэж, Леголас, Гимли хоёр Парт-Гален руу гүйлээ. Тэр хүртэл ганцхан бээр орчим байсан ч мань хоёр нэлээд удсаны дараа хоёр завьтай хүрч ирэв.

- Ёстой гайхалтай! - гэж Леголас хэлээд. - Хоёр завь маань байж байна, харин гурав дахь нь огт байгаагүй юм шиг алга болчихож.

- Орхууд аваад явчихсан хэрэг үү? - гэж Арагорн асуув.

- Юуны чинь орхууд! – хэмээн Гимли гараараа саваад. - Орхууд байсан бол нэг ч завь үлдээхгүй байсан ба ачаа тээшийг ч өөрийнхөөрөө янзлах байсан шүү дээ -гэлээ.

- За яахав, тэнд хэн ирээд явсныг би харна аа - гэж Арагорн амлалаа.

Боромирыг оршуулгын салан дээр эвтэйхэн хэвтүүлж, саарал эльф цуваар нь дэр хийв. Урт хар үсийг нь самнаж, хоёр мөр рүү нь бүтээв. Лориэний алтан утсаар нэхсэн хүрмийг нь эльф бүсээр нь бүсэллээ. Дуулгыг нь өмсгөж, цээжин дээр нь хугарсан илд, хагарсан бүрээ хоёрыг нь тавьж, хөл дор нь дайснуудын зэвсгийг овооллоо. Салыг завины араас чирч, их усанд орон хөвлөө. Тэгээд тэд Парт-Галены үзэсгэлэнт тохойг өнгөрөн гашуудлын хүчээр сэлүүрдэж, үд хэвийж байхад Рэросын хүрхрээнд дөхөж очлоо. Хүрхрээний усан цацал нарны туяанд солонгорч, цайвар шаргал манан үүсгэжээ. Их усны бөөн буулт салхигүй агаарыг доргион хүржигнэнэ.

Тэд салыг Андуины урсгалаар өмнө зүг рүү гунигтай тавилаа. Харьшгүй хүчит, хатан зоригт дайчин, хэнд ч бууж өгдөггүй зөрүүд Боромир мөнхөд тайвшран, хөвөгч булшин дээрээ хэвтсээр урсан одлоо. Үлдэгсдийн хажуугаар сал урсан өнгөрч, алтлаг манан дунд үзэгдэхгүй боллоо. Рэрос хүржигнэн хүрхэрсээр. Денэторын хүү Боромирыг их мөрөн нь ийнхүү авч одов. Өглөөн цагаар харуулд гардаг байсан Цагаан цамхаг, Минас-Тиритдээ тэр дахиж очсонгүй. Гэвч Гондорт нэгэн домог төрсөн бөгөөд түүнд өгүүлснээр эльфийн сал хүрхрээнүүдийн хажуугаар урсан өнгөрч, ачаагаа Осгилиатад хүргэн, Андуины үй олон салаануудын нэгээр мөнхийн одот тэнгисийн алс руу илгээсэн гэдэг билээ.

Гурван хадгалагч түүний араас үг дуугүй харсаар үлдэв. Тэгээд Арагорн.

- Түүнийг Цагаан цамхгийн өндөр дээрээс дахиад олон жил харж, алсын уулсаас юм уу, тэнгисийн эргээс хүрээд ирэх байх гэж их удаан хүлээнэ. Гэвч тэр эргэж ирэхгүй – гээд үдэлтийн удаан намуухан аялгуут дууг анх түрүүн аялав.

Уудам Ристанийн тал,

Гэрэл цацарсан нугуудаар

Умрын салхи хэсүүчилж,

Уул мэт хэрэмд туллаа.

Уйгагүй хэсүүлч анд минь хэлээд өгөөч,

Сарны гэрэл, оддын гэгээнд

Боромир үзэгдээгүй биз?

Үзэгдсэн, би түүнийг харсан.

Долоон ширүүн урсгал даваад

Тэнгэр газрын савслага руу

Тэр яваад өгсөөн.

Тэр өрнө зүгт явсан. Магад өрнийн салхи анд минь

Тээг саадыг үл мэдэгч

Тэр вантанг харсан буй за.

Өө, Боромир минь! Өндөр хэрмийн дээрээс

Өчнөөн алс харагдаж байна, гэвч

Өөрөө л чи үзэгдэхгүй юм даа.

Цааш нь Леголас үргэлжлүүлэв.

Өргөн Андуины зуун салаанаас,

элст манхан, эргийн хясаагаар

Өмнийн салхи уулгалан довтолно.

цахлай мэт чарлана.

Өмнөдөөр сонин юутай вэ?

Өвдсөн мэт юунд ёолон чарлав?

Боромир - баатар вантан хаа байна?

үглэн дуулахыг чинь

үл ойлгоном би!

Байгаа үгүйг нь үл мэднэ би, бүү асуу,

Бараан эргийг цагаан болтол хучаад

Баларч тоос болсон

Баатруудын ястай нийлээ болов уу!

Наран шингэх зүгээс цахлайн чарлаан тод байна, Боромир!

Наран мандах зүгт харин чиний сураг л алга байна.

Дахиад Арагорн дуулав.

Удамт хаадын эвдэршгүй хэрэмнүүдээс,

Нэвтэршигүй хаалгануудаас

Умрын салхи хүрхрээ мэт хүржигнэн,

Уулгалсаар довтлон ирлээ.

Аварга хүчит салхи чи,

Аятай сайхан мэдээ авчрав уу?

Аянга мэт хүрхрэх чинь юусан билээ?

Аадар мэт нулимс

Араас нь асгахгүй биз?

Боромирын дайчин уриаг сонсов би,

Бас бүрээ нь хүнгэнэхийг сонсов,

Мөрний мандал дээгүүр,

Мөчрөөр хийсэн сал хурдалж,

Хагарсан бамбай, хугарсан илдийг нь,

Харьшигүй хүч, нугаршигүй зоригийг нь . -

Хаа холоос урсгахыг харлаа.

Боромир минь! Одооноос эхлээд

Орчлонгийн цаг элэх хүртэл

Унасан энэ газартаа чи,

Мөнхийн харуулд зогс доо!

Тэд Боромирыг тийнхүү үдэв. Тэгээд завиа эргүүлж, урсгал сөрөн Парт-Гален руу байдаг хүчээрээ сэлүүрдлээ.

- Дорнын салхийг та хоёр надад үлдээлээ. Гэвч би түүний төлөө дуугүй өнгөрье - гэж Гимли хэлэв.

- Зөв байна - гэж Арагорн хэлээд эрэгт үсрэн бууж.

- Минас-Тиритэд дорнын салхийг нүүрээрээ угтдаг юм, гэвч түүнээс мэдээ асуудаггүй. Бид Боромирыг сүүлчийн замд нь үдлээ, харин бидний зам хаа байна? - гээд тэр голын эрэг

орчмыг хэрэн явж түргэн бөгөөд анхааралтай ажиглаад.

- Орхууд энд ирээгүй байна, ирсэн бол тэд хавийн газрыг талхалж орхих байсан. Фродо алга болсноос хойш манай хоббитууд энд ирсэн эсэхийг би мэдэхгүй байна - гэв. Тэгээд мөрөн рүү аажим урсгалт горхи нийлсэн газарт эргэн ирж.

- Энд мөр арай тод байна. Нэг хоббит мөрөн рүү ороод буцаж гарсан байна. Харин яг хэдийд гэдгийг нь би мэдэхгүй байна.

- Чамд ямар нэг юм ойлгомжтой болж байна уу? – гэж Гимли асуув.

Арагорн шууд хариулсангүй. Хоносон буурин дээрээ очоод ачаа тээшийг шалгав.

- Хоёр үүргэвч алга байна. Нэг нь лав Сэмийнх байна, тэр хамгийн том, хүнд үүргэвч байсан юм. Ойлгомжтой, Фродо завь авсан байна, түүний хамгийн үнэнч найз бөгөөд зарц нь хамт явсан байна. Фродо биднийг өөрийг нь хайж байх хойгуур эргэж иржээ. Би уулын хажууд Сэмийг гүйцээд миний араас гүй гэж хэлсэн юм. Гэтэл тэр гүйсэнгүй. Эзнийх нь толгойд юу байгааг тэр тааж мэдээд, яг цагаа олж эргэж иржээ. Фродо Сэмээс зугтаж чадсангүй, тэрнээс тийм амар сална гэж байхгүй!

- Тэр яагаад биднээс зугтаадаг байна аа? Баяртай ч гэж хэлдэггүй юм уу? Дахиад л нэг оньсого - гэж Гимли гайхав.

- Оньсого биш ээ, хариулт нь – гэж Арагорн хэлээд.

- Сэмийн зөв юм шиг байна. Фродо хэнийг ч дагуулж, Мордор руу, гарцаагүй шахам үхэл рүү явахгүй гэж шийдсэн байна. Харин өөрөө бол ямар ч байсан явах ёстой гэдгээ ойлгосон байна. Нэг л юм тохиолдсон байна, тэгээд л тэр айдас, эргэлзээ хоёроо давжээ.

- Магадгүй, орхуудаас зугтсан юм болов уу? - гэж Леголас асуув.

- Тэр зугтаах нь зугтаасан, гэхдээ орхуудаас зугтсан гэж би бодохгүй байна – гэж Арагорн өгүүлсэн боловч чухам юунаас зугтаасныг нь хэлсэнгүй, уг нь тэр юунаас зугтаасныг нь таамаглаж байлаа. Боромирын буруугаа хүлээж хэлсэн үг удаан хугацаанд нууц үлджээ.

- Нэг л юм тодорхой байна, Фродо энэ эрэг дээр байхгүй, тэр завь авсан байна, өөр хэн авах вэ, Сэм түүнтэй хамт хөвжээ, тэгээгүй бол түүний үүргэвчийг хэн авах билээ – гэж Леголас хэлэв.

- Сонголт ч энгийн боллоо, нэг бол үлдсэн завиараа Фродогийн хойноос хөөх, эсвэл орхуудын хойноос явган нэхэх. Тэгээд ч нэмэргүй дээ, өчнөөн цаг алдчихлаа - гэж Гимли өгүүлэв.

- Жаахан хүлээгээрэй, бодоод үзье! Би энэ удаа зөв сонголт хийх ёстой, тэгэхгүй бол бүх юм нэг л биш - гэж Арагорн хэлээд ямар нэг чимээ чагнаж байх мэт хэсэг зогссоноо.

- Орхуудын араас нэхэх хэрэгтэй. Би Фродог Мордорт хүргээд эцсээ хүртэл хамгаалах л байлаа, гэвч одоо байдал өөр болсон. Түүнийг мөрнөөр хайна гэдэг хоёр олзлогдогчийг

тамын үхэлд өгнө гэсэн үг. Зүрх маань надад хатуу хэлж байна. Бөгж хадгалагчийг одоо би хариуцах ёсгүй. Бид наймуулаа, есүүлээ чадах бүхнээ хийсэн. Одоо гурвуулаа хоёр нөхрөө аврах хэрэгтэй. Замдаа түргэн гарцгаая! Илүү ачаагаа нэг газар нууя - Өдөр шөнөгүй бараг амрахгүй шахам гүйх болно!

Тэд сүүлчийн завиа эрэг дээр гаргаж, шугуйд нуугаад доогуур нь илүү ачаагаа хийв. Тэгээд Парт-Галеныг орхиж, үдэш болоход Боромирын тэнцвэргүй тулаанд унасан газар ирлээ. Орхуудын мөрийг хайх хэрэг гарсангүй.

- Хэн явж өнгөрсөн нь тодорхой байна, тэд бохирдуулж, дэвсэлж, хугалж, хэмлэхгүйгээр явж чаддаггүй амьтад, замдаа тааралдсаныг байтугай тааралдаагүйг ч сүйтгэж явдаг - гэж Леголас заналтай хэлэв.

- Гэхдээ гайхалтай хурдан явдаг, ядарна ч гэж байхгүй. Одоохондоо мөр нь алган дээр байгаа юм шиг байна. Гэвч удалгүй зүлэг ногоо дуусна, цаашаа чулуу, хайрга л байгаа – гэж Арагорн хэлэв

- За тэгвэл хөөгөөд байна даа! – гномууд ч гэсэн явж сурсан, тэсвэр тэвчээрээр орхуудаас дутахгүй долоон голтой. Гэхдээ бид мөддөө тэднийг гүйцэхгүй, үүгээр явж өнгөрөөд нэлээд удсан байна – гэж Гимли хэлэв.

- Тийм ээ, бид гурав гурвуулаа долоон голтой гном байсан бол сайн санж. Гэвч юу л болбол болог, тааж ядаад байх юм алга, элдээд байна аа. Хэрэв бид тэднийг хөөгөөд гүйцвэл дайсанд үхэл ирнэ! Хөөцөлдөөн биш, тулалдаан болж, гурван чөлөөт ард түмэн - эльф, гном, хүмүүсийн тухай нэг домог төрнө. Урагшаа, гурван хурдан хөлт минь! – гээд Арагорн буга шиг дүүлэн харайснаа моддын дундуур гялалзан хурдлав. Түүний эргэлзээ шийдвэр төгс зоригоор солигдож, ядрахыг мэдэхгүй хурдаллаа. Леголас Гимли хоёр ч түүнээс хоцорсонгүй. Нуур орчмын ой төдөлгүй тэртээ ард хоцорч, гурван баатар хадархаг жимээр өгсөн жирийв. Баруун талд шингэх нарны сүүлчийн туяанд хөрөөний ир шиг иржгэр оройт уулс бараантан, харанхуйлж байгаа хад асганы хажуугаар гурван саарал сүүдэр жирэлзэн өнгөрч байв.

Бүлэг 2

Ристанийн морьт дайчид

Харуй бүрий боллоо. Ар талд ойрхон бэлээр модод манан дунд умбан, Андуины гэгээ татуулсан мандал мананд хучигдсан ч тэнгэрт гэгээтэй, одод жирвэлзэж, тэртээ баруунаас сар хөөрөн, хадан хясаанууд нүүрс мэт хар сүүдрээ унагаж байлаа. Хатуу хөрстэй эгц хажууд хүрээд, мөр алдахгүйн тулд хурдаа саах хэрэгтэй боллоо. Уулс тэртээ өмнө зүг рүү хоорондоо тасархай хоёр нуруу болон үргэлжилжээ. Баруун хажуу нь эгц хад асгатай, зүүн хажуу нь нарийхан гуу жалгаар хэрчигдсэн налуу ажээ. Тэд шөнөжин налуу өндөрлөгөөд өгсөөд дараа нь нэгэн өргөн хонхор руу уруудав. Үүрээс өмнөхөн тэнд зогсч амсхийлээ. Сар аль хэдийнэ далд орж, одод үзэгдэх төдий бүрэлзэн, дорно зүгээс үүр гэгээрлээ.

Арагорн бодол болон зогсов. Доош уруудсан дөнгөж үзэгдэх төдий мөрнүүд оргүй алга болжээ.

- Тэднийг хаашаа эргэсэн гэж чи бодож байна? Хэрэв хойшоо эргэсэн бол Фангорны ой руу шууд гүйгээд орчихно, тэндээс Изенгард хүртэл бараг ойгоор замнана, хэрэв тэд үнэхээр тэндээс ирсэн бол тийшээ явсан байж магадгүй биш үү? Эсвэл өмнө зүг рүү, Онтава руу явсан юм болов уу? - гэж Леголас асуув.

- Тэд хаашаа ч гүйлээ гэсэн мөрөн рүү чиглэхгүй – гэж Арагорн хариулав.

- Хэрэв Ристаниинхан бүгдээрээ хумхийн тоос болж, Саруман тэнд хаан суучихаагүй бол орхууд, миний бодоход, Мустангримын тал руу ухаан жолоогүй гүйнэ. Хойшоо эргэе!

Тэр хонхор яг хадан худаг мэт иржгэр хадан эргээр хүрээлэгдсэн бөгөөд ёроолоор нь багахан горхи том том бул чулуун дундуур урсана. Тал талаас хадан хясаа хашжээ. Тэд хойт зүг рүү лав нэг бээр газар таамгаар явлаа. Арагорн газарт наалдах шахан зүүн талын овгор товгор, хонхор хотгорыг шинжилж, Леголас урагш явлаа. Тэр гэнэт хашгирахад наад хоёр нь гүйж хүрэв.

- Заримынх нь араас хөөх ч хэрэггүй юм байна. Хараач!

Удаан урсгалт горхины хажуугийн бул чулуунууд дунд орхуудын хүүр байв. Таван орхыг хэрцгийгээр цавчсан байх ба хоёрынх нь толгой алга байлаа. Тунарсан цус нь бараг хатаагүй байна.

- Мөн хачин аа! Энд юу болсныг бүрэнхийд мэдэх боломж даанч алга даа – гэж Гимли дуу алдав.

- Юу ч болсон байлаа гэсэн бидэнд ашигтай. Орхуудыг хэн алах вэ, бидний нөхөд байж таарна. Эндхийн ууланд хүмүүс амьдардаг уу? – гэж Леголас асуулаа.

- Энд хүмүүс амьдардаггүй, - мустангримчуудад энд хийх юм байхгүй, Минас -Тирит ч хол.

Хойноос хэн нэг нь тэнэж яваад ирсэн байж мэдэх юм, гэвч яах гэж ингэх билээ? Үгүй ээ, хэн ч энд ирээгүй.

- Тэгээд хэн ингэсэн байж таарах вэ? - хэмээн Гимли гайхав.

- Тэд бие биедээ дайсан, үхдлүүд бүгдээрээ алс умардаас ирсэн байна. Нэгнийх нь ч бамбай дээр цагаан даль алга байна. Энэ бузрууд юм л бол үхэлдэн алалддаг. Цаашид хаашаа гүйх вэ гэж маргалдсан бололтой – хэмээн Арагорн дургүйхэн хариулав.

- Олзлогдогсдыг алчихаагүй байгаа, ядаж тэдэнд л бүү гар хүрээсэй - гэж Гимли сандрав.

Арагорн эргэн тойрныг нэгжээд юу ч олсонгүй. Тэд горхи дагаж явлаа. Одод шингэрэн бүдгэрч, үүрийн саарал гэгээ татав. Хойт талд чулуун дундуур садран урссаар хонхор руу орсон горхи бүхий том хавцал байна. Хоёр талаар нь тачир өвстэй, хатуу бутнуудтай ажээ.

- За энэ! Мөр олдлоо. Горхи дагаж дээш өгсчээ, маргаанаа шийдээд тийшээ явсан байна – гэж Арагорн заав.

Тэгээд нэхэгчид хавцал руу эргэж, шөнөжин унтаж амарсан юм шиг сэргэлэн цовоо болж, нойтон үхэр чулуунууд дээгүүр дүүлэн харайсаар нэгэн дүнсгэр ирмэг дээр гарч ирэв. Өглөөний жихүүн салхи тэдний үсийг босгон, нөмрөгийн хормой дэрвүүлнэ.

Тэд эргэж хараад, Их мөрний дээгүүр алсын оргилууд тодорч байгааг харлаа. Үр манхайтал цайж, хоорондоо дайсагнах мэт баргар оргилуудын дээгүүр нарны туяа тусав. Тэдний өмнө, баруун зүгт хязгааргүй тал манан дундаас тодрон гарч ирэв. Ристанийн ногоон тал цэлийж, сувдан өнгөт манан хөөрөн, тэртээ зүүн талд гуч орчим бээрийн цаанаас цасан оройт Цагаан уул өглөөн нарны туяанд гэрэлтэн тодров.

- Гондор! Хараач, Гондор! - хэмээн Арагорн дуу алдаад - хэрэв чамайг баяр баясгалантай цагт харж байгаа сан бол доо, Гондор орон минь! Одоохондоо би өмнө зүг рүү, чиний гэгээн урсгалууд руу чинь очиж амжихгүй нь.

Цагаан чулуун Гондор мину! Өрнийн салхи

Цаглашгүй эрт үед тэнгисийн зүгээс

Цагаан уул хүртэл үлээж ирсэн билээ л.

Эртний их хаадын эринд

Энд мөнгөн мод суулгаж,

Мөчир бүрээс нь цацрах

Мөнгөлөг гэрэл асан билээ л.

Аварга цамхгууд чинь сүндэрлэж,

Алтан жигүүрт титэм,

Алтан хаан ширээ чинь

Алдар суугаа өргөсөн билээ л.

Гондор минь, Гондор минь!

Мөнгөн модыг чинь дахин суулгаж

Мөнхийн гэрэл асаах болов уу?

Өндөр уулсын цуурайг

Өрнийн салхи авчрах болов уу?

- Урагшаа! – хэмээн тэр баруун хойт зүг рүү харцаа хандуулан захирав. Нэхэгчид хадан хавцлын ирмэг дээр зогсч байсан бөгөөд дөчин тохой дор өргөн арзгар, налуу, түүний цаана хадархаг эрэг байгаа нь Ристанийн Баруун хилийн шугам ажээ. Энэ бол мөрний эрэг дагуух уулсын сүүлчийн хавцал бөгөөд түүнээс цааш нүд хүрэх газарт баян тал үргэлжилнэ.

- Хараач! Дахиад бүргэд, маш өндөрт нисч байна - гэж Леголас цайвар тэнгэр рүү заагаад, энд нисч ирээд умард нутаг руугаа буцаж байгаа юм шиг байна. Салхийг гүйцэн нисч байна! Хараач, тэр байна!

- Үгүй дээ, миний анд Леголас, хараад ч яах юм билээ. Бид хоёр чам шиг нүдтэй биш. Хамгийн өндөрт нисч яваа биз. Мэдээж, мэдээ хүргэж яваа байх, ямар мэдээ хүргэж яваа юм бол доо, өчигдрийн миний харсан бүргэд биш байгаа даа? Харин чи тийшээ харсан нь дээр, тэр тэгш тал руу! Бидний хөөж яваа бузрууд тэнд гүйж байгаа юм биш биз? Олигтойхон хараад орхи!

- Тийм байна, тэнд бүх юм алган дээр байгаа юм шиг харагдаж байна. Шоргоолж шиг олон юм гүйлдэж байна, бүгдээрээ явган. Харин Бидний хөөж яваа бузрууд мөн бишийг ялгах юм алга. Арай л хол байна, арванхоёр бээрээс наашгүй. Их ч байж магадгүй, тал газар таамаглах хэцүү.

- Хэдэн бээр байсан ч хамаагүй, бидний хөөж яваа бузрууд мөн. Ямар ч гэсэн мөр хайх хэрэггүй боллоо. Ямар ч жимээр хамаагүй доошоо бууцгаая! – гэж Гимли шавдуулав.

- Ямар ч жим орхуудынхаас урт – гэж Арагорн хэлэв. Өдрийн гэрэлд мөр алдах аргагүй. Орхууд хөлийн чадлаар харайж, заваан талхны залждас, хар цувны уранхай сэг, хир даг болсон даавууны тасархай, задарсан тахтай гутал хаялан гүйсэн байв. Мөр хойт зүг рүү хөтөлж, дараа нь гүнзгий хонхор руу орсон ба тэндээс ширүүн урсгалт гол хүржигнэж байв. Жим эгц доошоо буугаад өтгөн өвсөн доогуур шургажээ.

Ингээд тэр гурав мөрний дагуух уулсын бэлээс эхэлсэн ногоон давалгаан дунд орлоо. Өтгөн, өндөр ургасан өвсөн дундуур шар ногоон уст горхинууд хоржигнон урссаар тэртээх Онтава

голын ай сав руу тэмүүлнэ.

Өвөл өндөр уулсын цаана үлдэж, энд урьхан салхи сэвэлзэн, шинэ шүүсээр дүүрэн хаврын ногооны дөнгөж мэдрэгдэх үнэрийг тарааж байлаа. Леголас удаан хугацааны зовлонт цангаагаа тайлж байгаа мэт анхилам агаараар уушгиа тэлтэл амьсгалав.

- Өвс ногоо нь ямар сайхан үнэртэй юм бэ! Нойр хулжих шиг болж байна. За хурдалцгаая! – гэж тэр хэллээ.

- Тийм шүү, энэ тал хөнгөн хөлтнүүдийн загатнасан газар маажна. Ямар тахтай гуталтай орхууд биш, одоо бид алдсан замаа нөхөж бага зэрэг урагшлах байх аа – гэж Арагорн хэлэв.

Тэд халуун мөрөөр орсон анч ноход шиг нүд нь очтон гялалзаж, ар араасаа гүйлээ. Баруун талд өвсийг нь гишгэчин давтсан хэсэг талбай харагдав. Гэнэт Арагорн нэгэнтээ дуу алдсанаа тэр зүг рүү гүйв.

- Хүлээж байгаарай, одоохондоо миний араас битгий яв! – гэж тэр хашгирав.

Тэр жижигхэн нүцгэн хөлийн мөр олж хараад тийш эргэсэн байжээ. Мөр холдсонгүй, тахтай том улын мөр араас нь дагаж, тойргоор эргээд гишгэгдсэн газарт алдагдав. Арагорн тэнд нэг эргээд, тонгойж өвсөн дотроос нэг юм аваад буцаж гүйв.

- Аа-ха, ойлгомжтой байна, хоббитын мөр байна. Пинийх л байх ёстой. Мерри арай өндөр. Энэ юу вэ, хараач!

Түүний алган дээр далдуу модны навч шиг ногоон юм гялсхийсэн нь ойгүй энэ тал газарт их л тод гоёмсог үзэгдэв.

- Эльф цувны товч байна! - гэж Леголас Гимли хоёр зэрэг дуу алдлаа.

- Кветлориэны навч унахдаа жингэнэн дуугардаг юм – гээд Арагорн инээвхийлж. - энэ товч аяндаа унаагүй, олуулах гэж унагасан байна. Пин амиараа дэнчин тавьж хажуу тийшээ гүйсэн бололтой.

- Тэгэхлээр амьд байна, толгой нь мөрөн дээрээ, хөл нь байдаг газраа байна. Хий дэмий гүйгээгүйдээ баярлалаа – гэж Гимли санаа амарсан аятай өгүүлэв.

- Эр зориг гаргасныхаа төлөө амиа өгчихөөгүй л байгаасай. Хурдалъя, хурдалъя! Манай хөгжилтэй хоёр залуу тэр мангаснуудын гарт байгаа цагт миний зүрх цээжиндээ байхгүй – хэмээн Леголас яарлаа.

Нар баруун тийш хэвийж байлаа. Тэнгисийн зүгээс үүлс ойртож, салхинд сарниж байна. Ар талаас урт сүүдэр унаж, нар жаргах цаг анзаарагдамгүй ойртжээ. Нэхэгчид нэгэн хэмээр хурдалсаар. Тэд Боромирыг үдсэнээс хойш нэг хоног өнгөрчээ. Гэтэл орхууд бас л хол байлаа. Хичнээн амьтан гүйж явааг уудам талд багцаалах аргагүй.

Бүрий болж байхад Арагорн түр зогсон амсхийв. Бүтэн өдөрт тэд хоёрхон удаа амьсгаа

дарсан, үүрийн гэгээтэй уулзсан тэр хавцлаас нааш арван хоёр бээр гүйсэн байлаа.

- Хүндхэн сонголт туллаа даа. Эндээ хонох уу, хүч, зориг байгаа дээрээ цааш гүйх үү?
- Орхууд хоноглож амрахгүй л болов уу, тэгвэл бид тэднийг бүр алдана – гэж Леголас хэлэв.
- Яагаад тэд амардаггүй юм бэ, тэд ч гэсэн амрах хэрэгтэй шүү дээ - хэмээн Гимли зөрлөө.
- Орхууд гэгээн цагаан өдөр гүйж байхыг хаана сонссон бэ? Гэтэл эд нар гүйгээд л байна, тэгэхлээр шөнө зогсохгүй.
- Бид харанхуйд мөрөө алдчихвал яана.
- Ийм мөрийг харанхуйд ч алдахгүй, хаашаа ч эргэхгүй чигээрээ явж байна шүү дээ.
- Мөр хөөж яваа хүн харанхуйд чигээрээ явах осолтой. Гэнэт тэд чиглэлээ өөрчилбөл бид хажуугаар нь гүйгээд өнгөрнө - гэж Арагорн хаширлаж. - дуртай ч, дургүй ч өглөө болохыг хүлээхээс – гэв.
- Бас нэг юм байна – гээд Гимли - Чиглэлээ өөрчилсөн мөрийг зөвхөн өдөр л харна, нэг хоббит нь зугтаадаг ч юм уу, аль нэгийг нь зүүн зүг рүү, Мордор руу чирээд явчихвал яах вэ? Тийм тохиолдлыг бид мэдэхгүй өнгөрч болохгүй.
- Бас л үнэн, - хэмээн Арагорн зөвшөөрөөд. - хэрэв би тэр алалдааны газар дээр алдаж таамаглаагүй бол, бамбай дээрээ цагаан дальтай орхууд дийлсэн, тэгвэл тэд одоо бүгд Изенгард руу гүйж байгаа. Би бараг алдаагүй юм шиг байна.
- Тэр муу орхуудыг ямар чөтгөр нь мэдэх вэ, харин Пин юм уу, Мерри яаж ийгээд зугтаж амжвал яана? Саяын товчийг бид харанхуйд олохгүй л байсан – гэж Гимли үг нэмэв.
- Орхууд одоо хоёр дахин сэрэмжтэй болсон, манай хоёр урьдахаасаа хоёр дахин ядарсан, бидний тусламжгүйгээр хоёр хоббит дахин зугтааж чадахгүй л болов уу. Гүйцвэл яаж ийгээд аварна, гүйцэх л хэрэгтэй, цаг алдаж болохгүй – гэж Леголас зөрсөөр.
- Гэвч би ихийг үзсэн тэнүүлч, гайгүй чанга гномын тоонд ордог, гэлээ ч гэсэн Изенгард хүртэл амрахгүй гүйж чадахгүй. Миний зүрх ч гэсэн байрандаа тогтохгүй байна, цаг алдалгүй гүйе гэж би анх санал гаргасан, харин одоо бол сайн амраад, маргааш хурдаа нэмье гэмээр байна. Бид амарья гэвэл шөнө л амрах ёстой – гэж Гимли хэлэв.
- Хүнд сонголт гэж би хэлсэн шүү дээ. Тэгээд яаж шийдэх вэ? – гэж Арагорн асуув.
- Чи бидний удирдагч, тэгээд ч чи хамгийн туршлагатай, чадвартай. Чи шийд – гэж Гимли хариулав.
- Би саатмааргүй л байна. Гэвч эсэргүүцэхээ больё, хэлснээр чинь больё - гэж Леголас бууж өглөө.

- Тун ч бэрх цагт шийдвэр гаргах үүрэг тулгарлаа. Чулуун аваргуудыг өнгөрснөөс хойш би алдааг ар араас нь гаргаж байна – гээд Арагорн хэсэг дуугүй байснаа.

- Хоносон нь дээр байх, нүдгүй харанхуй шөнө болно. Мөрөө алдах юм уу, ямар нэг чухал юм мэдэхгүй өнгөрвөл засч болохгүй алдаа болно. Ядаж шинэ сар бүдэг, эрт гарна.

- Юуны чинь сар, тэнгэр тэр чигээрээ харанхуйд хучигдсан байна. Бидэнд нөгөө хатан хааны Фродод өгсөн шиг шидэт дэнлүү л хэрэгтэй байна!- гэж Гимли хэлэв.

- Хэнд тийм гэрэл хэрэгтэйг хатан хаан л мэднэ. Фродо хамгийн хүнд ачааг үүрч яваа. Бид яахав дээ... Энэ бэрх цагт бидний гүйх ч яамай байна. Магадгүй, бид огт хэрэггүй гүйж байгаа ч юм билүү, миний сонголт ч гэсэн юуг ч өөрчлөхгүй. Гэвч юу л болбол болог. Сонголт хийгдсэн. Өглөө оройноос цэцэн гэдэг биз дээ!

Арагорн өвсөн дээр тэрийн хэвтээд үхсэн мэт нам унтав. Тэрбээр Тол-Брандираас хойш хоёр хоног нүдээ аниагүй, тэр шөнө ч гэсэн унтаж чадаагүй билээ. Тэр үүрээс өмнөхөн сэрээд шууд босон харайв. Гимли тарвага шиг унтаж, Леголас хойт зүгийн харанхуй руу нүдээ шигтгэх мэт ажиглан, салхигүй шөнийн өндөр хус мод мэт хөдөлгөөнгүй, бодолдоо автан зогсч байлаа.

- Тэд биднээс гурван гурвын есөн бээрийн зайд явж байна. Тэд хурдаа хасаагүй байна гэдгийг зүрх минь мэдэрч байна – гээд тэр Арагорн руу эргэж. - Одоо тэднийг бүргэд л гүйцнэ – гэв.

- Бид ч гэсэн оролдоод үзнэ дээ – гээд Арагорн бөхийж Гимлигийн мөр рүү алгадаж. - Босоорой! Хөөх цаг боллоо! Тэгэхгүй бол хөөх юм байхгүй болох нь! – гэв.

- Харанхуй байна шүү дээ, тэгэхэд нар гараагүй байсан бол Леголас тэднийг уулан дээрээс ч харахгүй л байсан – гэж Гимли үглэв.

- Одоо харна уу, байна уу, уулан дээрээс үү, биш үү, нартайд уу, сартайд уу хамаагүй, тэртэй тэргүй юу ч харагдахгүй – гэж Леголас бувтнав.

- Нүдэнд харагдаагүй юмыг чих сонсч болно – хэмээгээд Арагорн инээмсэглэж - Газар дэлхий тэдний хараалт уланд ёолж байна – гэв.

Тэгээд чихээ газарт наагаад хөдөлгөөнгүй болж, тэр чигтээ нэлээд удахад Гимли түүнийг ухаан алдчихав уу, унтаад өгөв үү гэж бодов.

Үүр гэгээрч эхэллээ. Эцэст нь Арагорн босч ирэхэд царай нь сааралтаж, хатуу ширүүн, дүнсгэр, санаа зовсон шинжтэй байлаа.

- Бөглүүд, бүдэгхэн чимээ л сонсдож байна. Эргэн тойронд олон бээр газарт хэн ч алга. Холдож байгаа дайснуудын хөлийн чимээ дөнгөж сонсдох төдий байна. Гэвч морьдын төвөргөөн тод сонсдож байна. Унтахаар хэвтэхэд морьдын төвөргөөн сонсдож байсныг би санаж байна. Морьд баруун зүг рүү давхиж байна. Энэ хязгаарт ер нь юу болоод байгаа юм бол?

- За хөдөлбө! - гэж Леголас яарав. Гурав дахь өдрийн нэхэлт ингэж хэллээ. Үүлэн бүрхүүл, хааяа нэг гялсхийх нарны доор бараг амьсгаа даралгүй гүйж, ядрахыг үл мэдэн хааяа хурдан алхаагаар гүйлтээ солин түр амарч байлаа. Хааяа нэг цөөн үг сольж явлаа. Тэдний зам өргөн тал дундуур гаталж, эльфийн цувны өнгө нь ногоон саарал өвс ногооны өнгөнд ууссан тэр гурвын тал дундуур гүйж байгааг нэлээд ойроос харсан эльфийн соргог нүд л олж харах байв. Гүйлт дундаа идсэн путлиб тэдний хүчийг дээд зэргээр сэлбэж, тэд Лориэний хатан хаанд үгээр илэрхийлшгүй ихээр талархаж явлаа.

Дайсны мөр бүтэн өдөр баруун хойт зүг рүү нэг ч эргэлт, хазайлтгүй чигээрээ хөтөлж байв. Нар жаргах дөхөж байх үеэр тэд урт, налуу, ойгүй толгодод хүрч ирэв. Орхууд хойт зүг рүү эгц эргэн тийш гүйсэн байх бөгөөд мөр нь бараг үзэгдэхгүй байв. Эндхийн хөрс хатуу, өвс ургамал сийрэг ажээ. Тэртээ зүүн талд Онтава гол ногоон талыг мөнгөн тууз мэт эмжин алсалжээ. Хичнээн ч харсан амьд амьтад байх шинжгүй.

Ристанийн суурингууд голдуу Цагаан уулын өтгөн ойд байдаг боловч урьд нь адуучид тоолшгүй олон сүргээ Мустангримын зүүн өмнөд хязгаарын үржил шимт талд адуулж, өвлийн цагт ч гэсэн овоохой, майхан үй олноороо байдаг байжээ. Харин одоо энэ хязгаар яагаад ч юм эзэнгүй болжээ.

Бүрэнхий болж байх үеэр зогсож амрав. Тэд Ристанийн нуга хөндийнүүдээр хорин дөрвөн бээр гүйжээ. Будант тэнгэрт шинэ сар цайвартан гэрэлтэж, одод будангийн цаанаас бүдэгхэн жирвэлзэв.

- Бидний саатал, алгуурлалт бүхнийг хараал идээсэй! - хэмээн Леголас өөртөө хэлж. - Орхууд биднээс бүр холдоод талийсан. Саурон өөрөө тэднийг ташуурдан хөөж яваа юм шиг галзуу мэт хурдалж байгаа, одоо ойд аль хэдийн хүрчихсэн, уулын харанхуй шугуйгаар гүйж байгаа, тэндээс тэднийг олно гэдэг гонж! – хэмээн халаглан байв.

- Бид шал дэмий юманд найдаж, шал дэмий байдаг хүчээ шавхлаа - хэмээн Гимли шүдээ зууж, сийгүүлэн хэлэв.

- Шал дэмий юманд найдаагүй ч байж болно, хүчээ шавхах хаа ч байсан юм бэ - гэж Арагорн түүний үгийг таслаад. - Урд маань урт зам байна. Гэхдээ би үнэхээр ядарлаа - гээд хар саарал мананд умбасан зүүн зүг рүү эргэж харав.

- Эндхийн газарт ч нэг л базаахгүй юм болж дээ, дэндүү нам гүм, сар хүртэл бүдэг, одод дөнгөж л гэрэлтэж байна. Би ингэж их ядарч байснаа ер санахгүй юм, Мөр нэхэлтийн ид дунд унаад өгвөл баларна гэсэн үг. Хэн нэгний хорон хүч дайснуудад хүч чадал өгөөд, бидэнд үзэгдэж харагдахгүй саад хийгээд байна. Бие махбод төдийгүй зүрх сэтгэлийг дарамтлаад байна - гэлээ.

- Юу ч биш! Би бүр замд гарахдаа л тийм юм мэдэрсэн, биднийг араас биш, урдаас дараад байна - гээд Леголас Ристанийн будант талын дээгүүр нарийхан хөмсгөн сар бүдэгхэн гэрэлтэж байгаа баруун зүг рүү дохив.

- Саруманы хар шид - гэж Арагорн хэлээд – За яахав, тэр биднийг буцаагаад явуулчихаж

дөнгөхгүй, одоо хонохоос аргагүй, үүл сарыг залгичихлаа. Зам маань толгод, намаг дундуур хөтөлнө. Үүрээр хөдөлье.

Хамгийн түрүүнд Леголас босдогоороо босов.

- Сэрцгээгээрэй! босцгоогоорой! Аль хэдийнэ үүр хаяарч байна. Фангорны ойн чөлөөнд жигтэй сонин мэдээ биднийг хүлээж байна. Сайн мэдээ юу, муу мэдээ юу мэдэхгүй, гэвч алгуурлаж болохгүй. Босоцгоо!

Нөгөө хоёр нь ухасхийн босч тэд шууд л замдаа орлоо. Бага үд болохоос өмнө тэд хойт зүг рүү эгц харсан нүцгэн уулын ногоон бэлд тулж очив. Хөл дорх хуурайвгар хөрст газарт өтгөн өвс ургаж, зүүн талд арваад бээрийн цаана зэгсэн шугуй болон Онтава голын хөндий мананд хучигдсан харагдав. Хамгийн урд талын толгойн дэргэд орхууд маш том хүрээ үүсгэн газрын хөрсийг талхалжээ. Тэдний мөр дахиад хойт зүг рүү хөтлөв. Талхлагдсан газрыг тойрч хараад.

- Энд тэд нэлээд удаан амарсан байна. Гэхдээ л биднээс хангалттай хол түрүүлжээ. Чиний зөв байх гэж айж байна, Леголас. Гурван удаа арванхоёр цаг өнгөрсөн байна. Хэрэв тэд хурдаа хасаагүй бол өчигдөр орой Фангорны ойн чөлөө хүрсэн.

- Хаашаа л харна утаан өнгөт өвс, толгой дээр гарвал ямар нэг ой шугуй харагдах болов уу? – гэж Гимли үглэв.

- Харагдахгүй ээ, толгод эндээс хойшоо найман бээр үргэлжилнэ, Онтава хүртэл талаар арвантаван бээр орчим явна – Арагорн хэлэв.

- Тэгвэл урагшаа, хөл маань л битгий сөхөрчихөөсэй, тэгэхгүй бол зүрхэн дээр нэг юм дараад байна.

Амралтгүй гүйсээр нар шингэх үест толгодын хойт захад хүрэв. Одоо тэд гүйх биш гэлдэрч, Гимли бүр бөгтийжээ.

Гномууд аян замд ч, ажил хөдөлмөрт ч ядрахыг үл мэдэх боловч эцэс төгсгөлгүй бөгөөд найдваргүй гүйлт түүнийг туйлдуулжээ. Баргар царайлж, дуугаа хураасан Арагорн түүний араас гэлдэрч, байн байн ямар нэг тэмдэг харж явна. Ганц Леголас л ямагт байдгаараа өвсөн толгойг дөнгөж бөхийлгөн хөнгөн салхи мэт алхалж байв. Лориэний аян замын талх түүнийг цадтал найдвартай тэжээж, дээр нь бас явуут дундаа нүдээ анилгүй нойр авч чадаж байв.

- Тэр ногоон толгой дээр гараад эргэн тойрныг харъя гэж тэрбээр ядарсан хоёр найздаа хэлээд арай онцгойдуу байгаа захын толгой өөд алхав. Тэр хооронд нар жаргаж, үдшийн цагаан гэгээ тасраад бүрэнхий болов.

- Чиний эргэн тойрныг хардаг ч өнгөрлөө, харин энд хононо оо, сүрхий хүйтэрч байна! – гэж Гимли хэлэв.

- Цаст оргилуудаас умрын салхи үлээж байна – гэж Арагорн хэлэв.

- Өглөө гэхэд дорнын салхи үлээнэ. Амарцгаая даа. Гэхдээ Гимли чи итгэл найдвараа алдах

болоогүй шүү. Маргааш юу ч болоо билээ. Өглөөний нар замыг тодруулдаг гэдэг дээ – гэж Леголас өгүүлэв.

- Гурван өглөө дараалан тодрууллаа, ашиг нь юу байна? – хэмээн Гимли үглэв.

Хүйтэн шөнө болж, Арагорн Гимли хоёр унтаж байгаад сэрэхэд Леголас нэг бол хөдөлгөөнгүй зогсч, нэг бол эртний хэлээрээ аяархан дуулан, хойш урагш алхаж байгаа үзэгдэнэ. Ийнхүү шөнийг өнгөрөөгөөд үүрийн гэгээг хамтдаа угтлаа. Үүлгүй цонхигор тэнгэрийг үүрийн туяа гийгүүлж, удалгүй нар мандав. Салхи дорноос үлээж, манан буданг хөөгөөд, дүнсгэр талыг нүцгэлэв.

Тэдний өмнө Ристанийн уудам тал дорно тийш цэлийж байв. Энэ талыг тэд хэд хоногийн өмнө Андуинаар хөвж явахдаа хальтхан харсан билээ. Баруун хойт талд Фангорны их ой бараантаж, захад нь хүрэхэд арван бээрээс багагүй зай харагдана. Түүнээс цааш, Манант нурууны хамгийн захын оргил Метхедрас үүл цоолон сүмбэрлэжээ. Ойгоос нааш Онтавагийн эх түргэн урсгалт нарийвтар гол эгц өндөр эргийнхээ хоорондуур урсаж байна. Орхуудын мөр тоглодоос тэр зүг рүү чиглэжээ.

Арагорн гол хүртэл мөр шинжээд, дараа нь голын эх өөд харж байтал хязгааргүй ногоон талд ганц хамхуул өнхөрч байгаа юм шиг бүдэгхэн цэг олж харав. Тэгээд газарт чихээ наан чагналаа. Дэргэд нь Леголас ирж зогслоо. Тэр нарийхан урт алгаараа тэр зүг саравчлан хараад эльфийн хурц хараагаараа тэр бол цэг ч биш, сүүдэр ч биш, харин жижигхэн морьтнууд, маш олон морьтнууд довтолгож байгааг үзэв. Тэдний жаднууд нуман нүдтэнд харагддаггүй өдрийн одод мэт гялалзаж үзэгдэв. Тэдний ард тээр цаана хар утаа олгойдож байна.

Эзэнгүй тал нам гүм хэвээрээ, салхинд өвс сэрчигнэж байгааг Гимли сонсч байв.

- Морьтнууд! - гэж Арагорн дуу алдаад үсрэн босч. - Морьтнуудын том бүлэг биднийг чиглэн ирж явна - гэлээ.

- Тиймээ – хэмээн Леголас батлаад. - Морьт дайчид. Тоогоор таван зуу орчим юм байна. Тэд шар үстэй, жаднууд нь тод гялалзаж байна. Удирдагч нь их өндөр хүн байна.

- Эльфүүд мөн ч хол харах юм даа - гээд Арагорн инээмсэглэв.

- Холсоод байх юу байхав дээ, биднээс таван бээр орчим зайтай ирж байна - гэж Леголас тоомжиргүй хэлэв.

- Таван бээр байна уу, зуун сажин байна уу, тэртэй тэргүй бид тэднээс нуугдаж чадахгүй, эндээ зогсоод хүлээх үү, замаараа явах уу? – гэж Гимли асуув.

- Хүлээнэ ээ, би ядарч байна, орхуудыг бид гүйцэхээсээ өнгөрсөн. Биднээс урьтаад орхуудын учрыг олчих шиг боллоо. Морьтнууд дайсны мөрөөр наашилж байна. Тэд бидэнд мэдээ авчирч яваа ч байж магадгүй – гэж Арагорн хэлэв.

- Эсвэл илд жадаар уулзаж ч магадгүй - гэж Гимли үг нэмэрлэв.

- Гурван морь эзэнгүй мөртөө эмээлтэй байна, гэхдээ хоббитууд үзэгдэхгүй байна - гэж Леголас мэдээлэв.

- Би сайн мэдээ авчирна гэж хэлээгүй, сайн ч бай, муу ч бай ирэхээр нь мэдье - гээд Арагорн түүн рүү эргэж харлаа.

Тэд толгойн орой дээр дэндүү ил байсан тул яаран доош бууж, хойт бэлийн өвсөрхөг дов дээр очоод нөмрөгөөрөө хучиж, зэрэгцэн суулаа. Жихүүн салхитай байв. Гимли байж сууж ядна.

- Чи энэ адуучдын талаар юу мэдэж байгаа юм бэ, Арагорн, бид зүгээр үхлээ хүлээж суугаа юм биш биз? – гэж тэр асуулаа.

- Миний мэддэг ардууд аа, бардам зөрүүд, эрх дураараа, гэхдээ өгөөмөр зантай, үг үйл хоёр нь хэзээ ч зөрдөггүй, тулаанд эрэмгий мөртөө цусанд шунадаггүй, ухаалаг мөртөө бүдүүлэгдүү. Ном судар байдаггүй, тэгсэн мөртөө үүх түүх өгүүлсэн дуунуудаа толгой дараалан мэддэг ард түмэн. Би энд ирээгүй их удаж байна, урвагч Саруманы гар хөлүүд худалдаад авчихсан байж ч мэднэ, Сауроны аюул занал сөхрүүлсэн ч байж магадгүй. Гондорчуудтай цусан төрөл биш боловч өнө эртний найрамдалтай, ер нь өвөг дээдэс нь умар зүгээс эрт цагт ирсэн. Умардынхантай адил өндөр нуруутай, цагаан шаргал үстэй хүн олон. Аль аль нь орхуудын дайсан.

- Гэндальф эднийг Мордорт алба төлдөг гэсэн яриа бий гэж байсан – гэж Гимли хэлэв.

- Боромир үүнд итгэхгүй байсан, би ч итгэхгүй байна.

- Одоо хэнийх нь зөв болохыг үзэж дээ. Одоо тэдний чимээ сонсдож байна – гэж Леголас дүгнэв.

Морьдын төвөргөөн ойртож байгааг Гимли хүртэл сонсов. Морьтнууд голоос нааш эргэж, орхуудын мөрөөр салхитай уралдан давхилдлаа.

Алсаас тэдний хүчирхэг залуу дуу хоолой сонсдож, гэнэт толгодын цаанаас бөөнөөрөө довлон гарч ирэв. Удирдагч нь цэргүүдээ өмнө зүг рүү, баруун бэлээр залан давхилаа. Шилж сонгож авсан юм шиг хуяг дуулгатай, чилгэр чийрэг дайчид түүний араас мөнгөлөг цуваа болон хөвөрнө.

Дэлийг нь самнасан, сувдан саарал өнгөт нөмрөгтэй өндөр морьд нь дэл сүүлээ намируулан хурдална. Эзэд нь морьдтойгоо адилхан чацархаг, бардам тэргүүнээ өргөж, дуулган дороос нь цагаан шаргал үс нь намирч байна. Дайчин бүр урт модон ишт жад барьж, нуруундаа угалз хээтэй бамбай хөдөрч, бүсэндээ урт илд зүүсэн бөгөөд хөө хуяг нь өвдөгтөө хүрсэн байлаа.

Тэд хоёр эгнээ жагсаалаар давхин өнгөрч байсан бөгөөд зарим нь дөрөөн дээрээ босч, орчин тойрныг соргог нүдээр нэгжиж байсан боловч тэднийг нүд салгалгүй ажиглаж байгаа эльф цувтай харийн гурвыг харсангүй. Морьтнуудыг хажуугаар нь өнгөрч бараг дуусах үед Арагорн

ГЭНЭТ БОСООД.

- Ристанийн морьт дайчид аа, умардаас мэдээ байхгүй юу? – хэмээн чанга дуугаар асуув.

Морьтнууд нэгэн зэрэг жолоогоо татаж, хоромхон зуурт тэр гурвыг тойрон бүслэв. Гурван дайчин тал талаас сэрийсэн жаднуудын хүрээнд оров. Арагорн дуугүй зогсч, хоёр дагуул нь ихэд хянуур хөдөлгөөнгүй зогсоод түүний яахыг хүлээж байв.

Морьтнууд тушаал өгсөн мэт нэгэн зэрэг жадаа өрж, нумаа сумлалаа. Тэдний хамгийн өндөр, дуулганыхаа орой дээр цагаан адууны сүүл хийсгэсэн нэг нь урагш давшин, жадны үзүүр нь Арагорны цээжийг шүргэх шахан зогсов. Цаадах нь өчүүхэн ч хөдөлсөнгүй.

- Та нар хэн бэ? Яах гэж энд тэнэж ирсэн юм бэ? – гэж тэр Дундад газрын нийтийн хэлээр асуулаа. Түүний аялга, дууны өнгө яг Гондорын эрэлхэг бардам баатар ван Боромирынх шиг хатуу, эрсхэн ажээ.

- Намайг Тэнэмэл гэдэг, би Умардаас ирсэн, орхуудыг агнаж явна - гэж Арагорн хариулав.

Морьтон эмээл дээрээсээ үсрэн буулаа. Өөр нэг нь ухасхийн дэргэд нь ирж зогсоход түүнд жадаа өгөөд, илдээ сугалан Арагорны урдаас тулах шахам зогсч, гайхсан харцаар нэвт шувт ширтэв.

- Бид эхлээд та нарыг орхууд гэж бодлоо. Харин одоо тэднийх биш гэдгийг чинь харж байна. Гэвч та нар ч ядруухан анчид байна даа. Тэднийг гүйцээгүй нь та нарын аз болж. Тэд их хурдан гүйж байсан, зэр зэвсэг нь ч гомдохооргүй юм билээ, махир сэлэм нь бүр ч гойд. Та нар санамсаргүй тэднийг гүйцсэн бол тэр дороо анчин биш, ан болох байсан. Гэхдээ, Тэнэмэл чи нэг л биш дээ, нэг л хачин байна – гээд ядарч зүдэрсэн мөрчийг анхааралтай харцаараа сонжив. - Чамд энэ нэр чинь ч зохихгүй юм байна. Хувцас чинь ч хачин байна. Та нар өвсөнд нуугдах гэж ийм юм өмссөн юм уу? Бид яагаад та нарыг харсангүй вэ? Эсвэл та нар эльфүүд юм уу?

- Бидний дунд эльф ч бий. Энэ бол умардын Бөглүүд ойгоос ирсэн Леголас. Бидний зам Кветлориэнээр дайрсан, Ариун хязгаарын хатан хаан биднийг ивээлдээ авч, хэрэгтэй бүх зүйлийг маань бэлэглэсэн.

Морьтон нүдээ онилгон байж, тэднийг бүр ч ихээр гайхан харав.

- Алтан ойн шидэт хатан хааны тухай хуучны үлгэрт тэгэхээр худлаа хэлээгүй болж таарч байна уу! – гэж тэр хэлээд – түүний гараас амьд гардаггүй гэсэн биз дээ, нэгэнт тэр та нарыг ивээлдээ авч, бэлэг сэлтээр хангасан юм бол та нар ч бас идтэн шидтэн, илбэчин шавираачин байх нь ээ? - гэснээ Леголас, Гимли хоёр руу хүйтнээр харж. - Та хоёр яагаад дуугарахгүй байна, дуугүйчууд аа?

Гимли хөлөө бат гишгэж, байлдааны сүхнийхээ ишнээс атгав. Хар нүд нь хилэнтэйеэ гялалзана.

- Өөрийнхөө нэрийг хэл, адуучин минь, тэгвэл миний нэрийг сонсоно, бас дашрамд нь бас бус юм ч сонсох вий.

Өндөр дайчин намхан гномын дээрээс дооглонгуй харж.

- Уг нь харийн этгээд чи эхэлж нэрээ хэлэх ёстой, гэвч чинийхээр больё... Миний нэр Эомундын хүү Эомер, миний цол – Мустангримын гурав дахь жанжин.

- Тэгвэл сонс, Эомундын хүү Эомер, Мустангримын гурав дахь жанжин минь, чамд Глоины хүү Гимли хэлж байна. Үүнээс хойш дэмий үг бүү унагаж бай, чамаас тэнгэрийн од шиг хол байгаа юмыг бүү дураараа шүүх гэж оролд, эс тэгвээс энэ удаагийнх шиг зөвхөн охор ухаан чинь чиний аврал болохгүй гэж мэд.

Эомерийн нүд зэвүүтэй гялалзаж, ристанчууд Гимлийн хэлсэн үгэнд дургүйцлээ илэрхийлэн дүнгэнэлдээд, дахин тал талаас нь жадны үзүүр шивээлэн хүрээлэв.

- Би нэг далайлтаар чиний толгойг хууз сахалтай нь хусаад хаячихмаар байна, эрхэм хүндэт гном минь, даанч толгой чинь газраас дээш үзэгдэхтэй үгүйтэй юм даа – гэж Эомер шүднийхээ завсраар сийгүүлэн хэлэв.

- Харин чи сайн хар л даа, энэ бол чиний амьдралдаа харах хамгийн сүүлчийн юм – гэж Леголас хэлээд нүд ирмэх зуурт нумаа онилов.

Эомер илдээ далайж, хэрэв Арагорн байгаагүй бол яах аргагүй муугаар дуусах байлаа. Арагорн тэдний дундуур ухасхийн ороод гараа өргөж.

- Бүү хилэгнэ, Эомер! Арай илүүг сонсч мэдээд чи миний дагуулууд яагаад чамд уурласныг ойлгох болно. Бид Ристаничуудад муу санаа өвөрлөж ирээгүй. Хүмүүст нь ч, адуунд нь ч. Цавчихаасаа өмнө миний үгийг сонсоно уу?

- Сонсьё - гээд Эомер илдээ буулгаж. - гэлээ ч гэсэн энэ цөвүүн цагт Ристанийн газар нутагт хэрэн бэдэрч ирэгсэд жаахан ухаалаг байх хэрэгтэй. Эхлээд чи жинхэнэ нэрээ хэл.

- Эхлээд чи хэнд зүтгэдгээ хэл, Мордорын хар эзэн Сауроныхан хамсаатан уу, дайсан уу?

- Би зөвхөн өөрийнхөө эзэнд – Тэнгэлийн хүү, эзэн захирагч Теоденд зүтгэдэг, харин алсын харанхуйн хөшигний цаадах эзэнтэй бид холбоо сүлбээгүй, гэхдээ бид тэдэнтэй дайтаагүй байна. Хэрэв чи түүнээс зугтаж яваа бол эндхийн хязгаарыг үтэр түргэн орхи. Манай хил тайван биш, газар сайгүй аюул заналхийлж байна. Бид ердөө л өөрийнхөө эрх дураар амьдарч, өөрийнхөө газар нутагт эзэн байхыг хүсдэг, бидэнд харийн эзэд сайн ч бай, муу ч бай хэрэггүй. Урьд өмнө бид аян замын хүмүүсийг зочилж хүндлээд явуулдаг байсан, одоо бол урилгагүй зочдоос түргэн салах даалгавартай. Тэгээд чи хэн юм бэ? Хэнд зүтгэдэг юм бэ? Хэний даалгавраар манай нутагт орхуудыг мөрдөж яваа юм бэ?

- Би хэнд ч үйлчилдэггүй, гэвч Сауроныхан гар хөл, нүд чих бологсдыг ямар ч хил хязгаарт ялгаагүй, хаа сайгүй мөрддөг. Орхуудыг надаас илүү мэддэг хүн байхгүй л болов уу, тэгээд ч

би тэднийг өөрийнхөө хүслээр мөрдөөгүй. Одоо бидний мөрдөж байгаа бузрууд миний хоёр найзыг олзолсон юм. Нэгэнт ийм болохоор явган ч бай, унаатай ч бай тэдний араас эргэж харалгүй хурдлах ёстой, энэ талаар хэнээс зөвшөөрөл авах билээ. Дайсны тоог эхлээд авах аргагүй, дараа нь тас цавчсан толгойг нь тоололтой биш. Би зэвсэгтэй – гээд Арагорн нөмрөгөө хуу татав. Эрдэнийн чимэгт эльф гялалзаж, Андрил илдний хурц ирнээс хүчирхэг дөл бадран улалзав.

- Элендил! – гэж Арагорн огцом хашгираад. - Би Арагорны хүү Арагорн, миний нэр Элессар, Эльфийн Берилл, Дунадан. Би – Гондорын их хаан Элендилийн хүү Исилдурын угсаа залгамжлагч. Түүний тулалдаанд хугараад дахин давтсан илд энэ байна! Чи хэн бэ – миний холбоотон уу эсвэл саад тотгор уу? Сонголтыг өөрөө хий!

Гимли, Леголас хоёр нүдэндээ ч итгэсэнгүй. Анд нөхрөө ийм байхыг урьд нь тэр хоёр огт хараагүй билээ. Эомер жижгэрч, Арагорн өсөх шиг болж, царайд нь их эрх мэдэл, эртний хаадын агуу сүр хүч гэрэлтэв. Леголас түүний тэргүүнд туяа цацарсан цагаан титэм хормын төдийд гялсхийхийг харлаа.

Эомер арагш нэг алхаж, бардам харцаа хүндэтгэлтэйгээ доошлуулав.

- Мөн ч гайхалтай цаг ирж дээ, үлгэр домог өвсөн дотроос өөрөө босоод ирэх юм – гэж Эомер өгүүлээд Арагорнд хандаж. - Надад хэлээд өгөөч, ноён минь. Юу чамайг нааш нь дуудаа вэ? Үг яриа чинь хатуу ширүүн бөгөөд бүрхэг байна. Домогт өгүүлсэн зөгнөл үнэн эсэхийг мэдэхээр Денэторын хүү Боромир харийн газарт явсан юм, түүний морь эзэнгүй эргэж ирсэн. Чи умардын зөгнөлийн мэдээч. Тэр бидэнд юу гэж хэлж байна?

- Сонголтоо хий гэж хэлж байна. Тэнгэлийн хүү Теоденд дайнаас зайлж чадахгүй гэж хэл, нэг бол Сауроны холбоотон болно, эсвэл түүний эсрэг дайтна. Одоо хэн ч хуучнаараа амьдарч чадахгүй, миний гэж бодож байсан юмаа өөртөө үлдээж ч чадахгүй. Гэхдээ энэ тухай дараа ярья. Эзэн захирагчтай энэ талаар өөртэй нь ярилцах хэрэгтэй байна. Харин одоо надад цаг алга, надад чиний тусламж хэрэгтэй, ядаж зөвлөгөө чинь хэрэгтэй. Бид гурав найзуудаа чөлөөлөхөөр үй олон орхуудын араас хөөж явсныг чи сонслоо, ямар зөвлөгөө өгөх вэ?

- Миний зөвлөгөө бол – одоо хөөх хэрэггүй. Орхуудыг толгой дараалан устгасан.

- Андууд маань яасан бэ?

- Зөвхөн орхуудын хүүр л байсан.

- Нэг л ойлгомжгүй байна даа, та нар сайн харсан уу? Орхуудаас өөр хэний ч хүүр байгаагүй юу? Манай найзууд бол жижигхэн, бараг хүүхэд гэмээр, хөл нүцгэн, саарал хувцастай.

- Үхдлүүдийн дотор хүүхдүүд ч байгаагүй, гномууд ч байгаагүй. Бид үхдлүүдийг тоолсон, заншлынхаа дагуу хүүрнүүдийг овоолоод шатаасан. Одоо ч гэсэн шатаж дуусаагүй байх.

- Тэд бол хүүхэд ч биш, гном ч биш, - гэж Гимли хэлээд. - найзууд маань хоббитууд.

- Хоббит гэнэ ээ? - хэмээн Эомер учиргүй гайхаж. - Ямар хоббитууд? Ямар хачин нэрлэдэг юм бэ, та нар.

- Тэд уулаасаа хачирхалтай ардууд. – гэхдээ тэр хоёртой бид маш дотно андууд болсон юм. Харин хоббитуудын тухай та нар Минас-Тиритийг түгшүүлсэн тэр зөгнөлөөс мэдсэн байх ёстой. Тэнд. “...жижгүүд авахаар зориглосон...” гэж өгүүлсэн буй. Хоббитууд гэдэг бол тэр жижиг биетүүд.

- Жижиг биетүүд! – хэмээн Эомертой зэрэгцэн давхиж байсан морьтон инээгээд. - Жижиг биетүүд ээ гэж! Энэ чинь умардын хошин яриа, хүүхдийн дуунд гардаг одой нар биз дээ?

- Ёо ёо! Бид чинь гэгээн цагаан өдөр ногоон талаар давхиж байна уу, эсвэл үлгэрийн оронд ороод ирчихэв үү?

- Заримдаа ялгахгүй үе байдаг юм, бидний үеийн тухай үлгэрийг дараа үеийнхэн зохионо шүү дээ. Чи ногоон тал гэж сая хэллээ. Гэгээн цагаан өдрийн үлгэр гэдэг чинь энэ дээ!

- Бид удаан саатаж байна, жанжаан. Бид өмнө зүг рүү яарах ёстой. Харин энэ зэрлэгүүд зохиосон үлгэртээ хууртагдаж л байг. Эсвэл хүлээд эзэн захирагчид хүргэх үү?

- Тайвшир, Эотан! - гэж Эомер нутгийн хэлээр өгүүлээд. - Би эдэнтэй хэдэн үг солиодхоё. Тэгээд зам дээр гараад жагсч бай, Онтав руу явцгаая.

Эотан хамар дороо нэг юм бувтнаад, тушаал өгч, морьт дайчид нэлээд холдоод зам зээр жагсав. Гурван аянч Эомертой үлдлээ.

- Чиний ярьж байгаа юм үнэхээр гайхмаар боловч би үнэнийг ярьж байна, Арагорн! Энэ илт байна. Бид хэзээ ч худлаа хэлдэггүй учир биднийг хуурах амаргүй. Чи үнэн ярьж байгаа боловч гүйцэд ярихгүй байна. Чи бүгдийг ойлгомжтой ярихгүй болохоор би яаж сонголт хийх билээ?

- Олон долоо хоногийн өмнө бид Имладрисаас гарсан, Боромир зөгнөлийн хариуг авахаар Минас-Тиритээс тийшээ явсныг санаж байгаа биз дээ, бид Денэторын хүүтэй хамт явсан юм. Бид болох гэж буй дайнд Сауроны эсрэг мөр зэрэгцэн тулалдахаар шийдсэн байлаа. Гэхдээ бид есүүлээ, огт өөр маш чухал даалгавартай явсан. Тэр тухай би одоохондоо ярих эрхгүй. Биднийг Саарал Гэндалф удирдаж явсан.

- Гэндалф! – гэж Эомер дуу алдаад - Гэндалф Саарал Нөмрөгтийг манайд газар сайгүй мэднэ, гэхдээ одоо түүний нэрээр эзэн захирагчийн ивээлийг хүртэнэ гэж бүү сана. Тэр байн байн ирдэг байсан, заримдаа жилд хэдэн ч удаа ирнэ, заримдаа арван жилээр ч сураггүй болно. Ирэх болгондоо түгшүүрт мэдээ авчирдаг байсан, тиймээ одоо тэрнийг муу ёрын зарч гэж нэрлэдэг болсон. Өнгөрсөн зун манайд ирсэн юм. Тэрнээс хойш бүх юм буруугаар эргэсэн. Сарумантай муудалцлаа. Өнөөг хүртэл бид Саруманыг анд нөхрөө гэж үздэг байсан юм. Гэтэл тэр Изенгардад эзэн суугаад биднийг цавчих илд ирлэж байна гэж Гэндалф хэлсэн юм. Тэр өөрөө Ортханкад хоригдож байгаад гайхамшигт азаар аврагдсан юм билээ. Тэр Теоденаас тусламж гуйсан боловч Теоден татгалзсан. Эзэн захирагчтай уулзвал

Гэндальфийн тухай бүү дурс! Түүний уур хилэн намдаагүй байгаа. Учир нь түүнийг морь сонгож ав гэхэд Гэндальф Бэмарын шилмэл сүргээс хамгийн шилдэг Аянга нэртэй морийг сонгосон. Түүнийг зөвхөн эзэн захирагч л унах ёстой. Тэр үүлдрийн адууны дээд өвөг нь Эорла гэдэг хүний хэл мэддэг азарга байсан юм.

Долоо хоногийн дараа Аянга эргэж ирсэн боловч зэрлэгшээд, биендээ хэнийг ч ойртуулахаа больсон. Эзэн захирагч бүр ч их хилэгнэж байгаа.

- Тэгэхлээр Аянга алс умард хязгаараас эх нутагтаа гүйж ирсэн байх нь, тэнд Гэндальфаас салсан байна. Гэвч Гэндальф дахиад морь унахгүй. Тэр Морийн харанхуй нүхэнд үүрд үлдсэн.

- Гашуудалтай мэдээ байна. Надад болоод миний адил сэтгэдэг хүмүүст их гашуудалтай мэдээ байна. Гэвч олон хүн өөрөөр сэтгэдэг, эзэн захирагчтай уулзахаараа энэ тухай мэдэх болно.

- Энэ ямар их гашуудалтай мэдээ болохыг бүр чи хүртэл төсөөлөхгүй байгаа гэж би айж байна. Нэг сар ч өнгөрөөгүй байхад энэ аймшигт хүнд дарамт хүн бүрийн зүрхэн дээр бууна. Гэвч агуу ихүүд алга болоход жижгүүдийн үүрэг ихэсдэг. Ингээд л би отрядаа Морийн хаалганаас Кветлориэн хүртэл дагуулсан юм. Тэндээс Их мөрнөөр Рэросын хүрхрээ хүртэл явлаа. Эомер, чи энэ талаар эхлээд бүх үнэнийг мэдэж ав, дараа нь илүү үг битгий унагаарай. Тэнд Боромир алагдсан, түүнийг та нарын толгой дараалан хядсан орхууд алсан юм.

- Ээ, ямар их гай вэ! Минас-Тирит тийм гарамгай дайчнаа алдана гэдэг ямар их гай вэ! Тэргүүн зэргийн баатар байсан юм, газар сайгүй түүнийг бахдан биширдэг байлаа. Тэр манайд цөөхөн ирж байсан, Гондорын дорно хязгаарт тулалдаж байсан, цагаа ирэхээр агуу жанжин болох байсан нь эргэлзээгүй. Гэвч Гондор түүний мөхлийн тухай бидэнд мэдээ ирүүлээгүй шүү дээ. Хэзээ тийм юм болоо вэ?

- Дөрөв хонож байна. Тэр өдрийн оройноос эхлэн бид Тол-Брандирын бэлээс орхуудыг мөшгөж эхэлсэн.

- Яалаа гэнэ ээ, явганаар уу? – гэж ойлгоогүй Эомер гайхав.

- Тиймээ, явган явааг минь чи харж байгаа биз дээ? Эомерийн нүд гайхан бахархсандаа бүлтийв.

- Чамайг буруу нэрлэж байжээ, Арагорны хүү минь, чамайг Тэнэмэл биш, Жигүүрт хөл гэж нэрлэх ёстой байжээ. Цаг нь ирэхэд та гурвын энэ явган аян дайны тухай дуу зохионо биз ээ. Дөрөв хоног хүрэхгүй хугацаанд дөрвөн хорь дээр нэмэх нь таван бээр газар гүйжээ!

Элендилийн удмын булчин үнэхээр чанга юм аа! Ноёнтон минь, надад юу гэж тушаах сан бол? Эзэн захирагч хүлээж байгаа, надад сатаарах цаг алга. Дайчдын дэргэд би үг хэлээ цэнэдэг боловч одоохондоо бид Хар эзэнтэй байлдаагүй гэж би үнэн хэлсэн шүү. Эзэн захирагч маань богино бодолтнуудын үгэнд орж байгаа боловч бид дайнаас зайлах газаргүй. Гондор бол манай эртний холбоотон, бид тэднийг гай зовлонд орхихгүй, мөр зэрэгцэн

тулалдана. Ямар ч гэсэн би ингэж бодож байна, надтай ижил бодолтой хүмүүс олон бий. Би Ристанийн баруун хязгаарыг хариуцан хамгаалж байна, тэгээд л адуун сүргийг Онтавагийн цаана гаргахыг тушаасан юм. Адуугаа дагаад малчид нь нүүгээд явчихсан, одоо энд зөвхөн харуулууд л үлдсэн.

- Тэгэхлээр та нар Сауронд татвар төлдөггүй хэрэг үү? - гэж Гимли өөрийн эрхгүй асуучихав.

- Төлдөггүй, ер нь хэзээ ч төлж байгаагүй. Би ч иймэрхүү цуурхал сонссон. Гэхдээ ийм хол цуурхаж байгаа гэж бодоогүй шүү. Юу болсон бэ гэвэл хэдэн жилийн өмнө Хар газрын элч нар манайд ирж, адуу худалдаж авъя гээд маш их үнэ өгч байсан. Гэвч бид зөвшөөрөөгүй. Тэдэнд морьдоо зарж болохгүй. Тэд морьдыг их муухай болгодог юм. Тэгээд тэд манайх руу орхууд, шөнийн хулгайч нарыг олноор илгээж, олон морьд хулгайлуулсан. Дандаа хар зүсмийн морьдыг хөөдөг байсан, одоо манайд хар морь бараг байхгүй. Орхуудыг ч бид амархан учрыг нь олдог, цаашдаа ч тэгнэ. Дан ганц орхуудыг бол бид дөнгөлгүй яахав. Харин Саруманыг янзлах хэрэгтэй байна. Тэр өөрийгөө энэ хязгаарын хаан гэж зарласан, бид тэрэнтэй олон сар байлдаж байна. Тэрэнд есөн жорын орхууд захирагддаг, чонодолоох унасан орхууд ч байна, зөвхөн орхууд ч биш! Тэр Нэвтрэх хавцлыг хаасан, одоо хаанаас довлохыг бүү мэд, зүүнээс үү, баруунаас уу.

Тэр маш аюултай дайсан. Заль ухаантай, хүчирхэг шидтэн, хуурч мэхлэхдээ гарамгай, түүний царай бол үхэл. Хаана ч хамаагүй явж байдаг. Хоёр гурван газар зэрэг үзэгддэг, тэнүүлч өвгөн болж явдаг, юүдэнтэй нөмрөг цувтай, таяг тулж явна, хаанаас нь ч харсан Гэндальфтай адилхан – Гэндальфын дүрд тоглоод байгаа юм. Тэрний газрын тагнуулууд хаа сайгүй шиншилж байгаа, агаарын тагнуулууд нь бидний дээгүүр байнга эргэлдээстэй. Бидэнд юу тохиолдохыг мэдэхгүй байна, ямар ч гэсэн сайн юм харагдахгүй л байна. Яаж ч бодсон тэр бидний дундаас далд холбоотнуудаа олсон. Чи эзэн захирагчтай уулзах юм бол өөрөө үзнэ. Ер нь одоо бидэнтэй хамт яв, Арагорн! Чи биднийг гамшиг зовлон, эргэлзээн дунд байхад хүрээд ирсэн юм чинь миний дотор сүүмэлзсэн найдварын оч дэмий хоосон өнгөрнө гэсэн үг биш биз дээ?

- Боломж олдонуут очно – гэж Арагорн бүдэгхэн хэлэв.

- Үгүй ээ, одоо явъя! – хэмээн Эомер шавдуулж - Энэ бэрх цагт Элендилийн угсаа залгамжлах удам хүрээд ирвэл хөвгүүд ёстой нэг урам зоригоор жигүүрлэнэ дээ! Одоо баруун хязгаарт олон тулалдаан ар араасаа залган үргэлжилж байна, манайханд тун бэрх болно гэж би айж байна.

Умардын энэ байлдаанд ч би эзэн захирагчийн зөвшөөрөлгүйгээр, ордныг нь цөөхөн хамгаалагчтай үлдээгээд мордсон шүү дээ. Баруун хилээр гурав хоногийн өмнө орхуудын маш том бүлэг орж ирсэн, тэдний дотор бамбай дээрээ цагаан дальтай асар том орхууд явж байна гэж надад тагнуулчид мэдээлсэн. Тэд бол Саруманы цэрэг. Би хамгийн их айж байсан тэр сэжиг маань батлагдлаа гэж бодож байна. Ортханк, Хар цамхаг хоёр нийлчихлээ, тэд манай эсрэг нэгдээд, өөрсдийнхөө хувийн армийг байлдаанд оруулж байна. Бид орхуудыг хоёр хоног мөшгөөд, Онтвальдын ойн чөлөөнд нар шингэж байхад гүйцсэн. Тэнд тэднийг бүсэлж аваад өчигдөр үүрээр дайрсан. Хайран сайхан арвантаван дайчин, арванхоёр морь маань үрэгдлээ! Орхууд бидний багцаалж байснаас хавьгүй олон байсан. Дорноос, их мөрний

тэндээс цөөнгүй дайснууд тэдэнтэй нийлсэн байна. Бас ойгоос бамбай дээрээ цагаан дальтай асар том биетэнгүүд гарч ирсэн. Тэднийг бид мэднэ. Хамгийн харгис хэрцгий амьтад байгаа юм.

Ямар ч гэсэн бид тэднийг хиар цохилоо. Гэхдээ одоо өмнөдөд ч, өрнөдөд ч хүч хэрэгтэй байна. Чи үнэхээр бидэнтэй явахгүй гэж үү? Та нарт өгөх морьд байна. Эрин цагийн эргэлтэд сэргэж шинэдсэн чиний илдэнд хийх ажил зөндөө байна. Гимлийн сүх, Леголасын нум суманд ч бишгүйдээ л ажил байна. Алтан ойн эзэгтэйн талаар болгоомжгүй хэлсэн үгийг минь мартаарай. Би өөрсдийнхөө л ойлголтоор ярьсан, хэрэв буруу ярьсан бол илүү сайн мэдэж авна. Ярьж өгвөл их баярлана шүү.

- Сайхан үг хэлсэнд чинь их баярлалаа чамд, миний зүрх ч гэсэн чиний араас тэмүүлж байна, гэвч бид горьдлого байгаа цагт найзуудаа орхиж чадахгүй - гэж Арагорн хэлэв.

- Горьдлого байхгүй. Чи тэр хайж байгаа найзуудаа умард хязгаараас олохгүй – гэж Эомер түс тас хэлэв.

- Гэхдээ тэд ард үлдээгүй шүү дээ. Баруун хилийн ойролцоо бид ядаж тэр хоёрын нэг нь амьд, биднийг хүлээж байгааг илэрхий гэрчилсэн тэмдэг олсон. Гэхдээ, тэндээс толгод хүртэл ямар ч мөр олдоогүй, орхуудын явсан замаас ч, орчин тойрноос нь ч олдоогүй.

- Тэгвэл чинийхээр тэдэнд юу тохиолдсон байж болох вэ?

- Мэдэхгүй, тэд алагдсан байж болох юм, гэвч чи орхуудын хүүрэн дунд байгаагүй гэсэн. Чи андуу харна гэж үгүй л байх. Тулалдаан болохоос өмнө, бүр бүслэхээс чинь өмнө ой руу чирээд орсон байж болох юм. Та нарын бүслэлтээс нэг нь ч гарч чадаагүй гэж чи итгэлтэй хэлж байна уу?

- Тангарагласан ч болно, бид бүсэлж авснаас хойш нэг ч орх хаашаа ч гараагүй. Бид ойн чөлөөнд тэднээс түрүүлж хүрээд, бүслэлтээ хумьсан, хэрэв тэрнээс хойш хэн нэгэн бүслэлтээс гарсан бол лав л орх биш, эльфийн илбээр л гарчихдаг юм биш бол хэн ч гараагүй.

- Манай хоёр яг бидэн шиг хувцастай, та нар гэгээн цагаан өдөр бидний хажуугаар үзэлгүй өнгөрсөн шүү дээ.

- Нээрэн тийм шүү - хэмээн Эомер санаа авч. - эргэн тойронд үлгэрийн гайхамшиг болоод байхад өөртөө ч итгэх арга алга гэж би яагаад санаагүй юм бол? Ертөнц дээр бүх юм холион бантан болжээ. Эльф, гном хоёр хөтлөлцөөд манай тал хөндийгөөр зугаалж явна. Тэд Алтан ойн шидэт хатантай уулзсан мөртөө яагаа ч үгүй, амьд гараад ирсэн, харин ч дээр нь баахан бэлэг аваад гарсан, аль дивангарт, бүр бидний өвөг дээдэс Ристанид ирэхээс өмнө болсон байлдаанд хугарсан илд дахиад гялалзаж байна. Ийм цагт алдаа гаргахгүй, андуурахгүй байх арга байна уу?

- Ердийн л үргэлжлэл, - гэж Арагорн хариулаад - Сайн сайхан, муу муухай хоёр байраа сольчихоогүй байна. Урьд өмнө болж байсан үйл явдал л үргэлжилж байна, эрт цагт болоод

одоо, эльфүүд гномууд болоод хүмүүст энэ утгаар ялгаа алга. Зөвхөн нэгийг нөгөөгөөс нь ялгах л хэрэгтэй. Гэртээ байна уу, Алтан ойд байна уу.

- Чи үнэхээр зөв хэллээ – гээд Эомер. - Гэвч би чамд эргэлзээгүй итгэж байна, зүрхнийхээ зөн совингоор итгэж байна. Гэхдээ би дээрээ эзэнтэй хүн. Би хуульд захирагдана. Хууль эзэн захирагчийн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр харийн хэн ч бай Ристанид орохыг хориглосон. Өнөөгийн энэ цөвүүн цагт хууль зөрчвөл үхэл. Би чамайг хамт яв гэж сайн санаагаар гуйсан, чи зөвшөөрсөнгүй. Гурван дайчин хэдэн зуун жадны өөдөөс сөрнө гэж үү?

- Хууль хуулиараа, өөрийн толгой мөрөн дээрээ, тэгээд ч энд би харийн хүн биш. Танай энэ хязгаарт нэг биш удаа ирж байсан, Мустангримын морьт дайчдын жагсаал дунд орж танай дайснуудтай тулалдаж явлаа, гэхдээ өөр нэрээр, өөр дүрээр. Чамтай уулзаж байгаагүй, чи тэгэхэд хүүхэд байсан, гэвч Эомунд аавтай чинь сайн танил байсан, Тэнгэлийн хүү Теоденийг ч танина. Тэр цаг үед Ристаниин эзэн захирагчид миний ажил шиг чухал ажилд саад хийх тухай бодол толгойд нь ордоггүй байсан. Миний үүрэг тодорхой, миний зам шулуун. Яарч үз дээ, Эомундын хүү минь, хурдан шийд. Бидэнд тусал, ядаж эв найртай явуулчих. Эсвэл хуулиа биелүүлэх аргаа бод. Нэг зүйлийг хэлье. Хуулиа биелүүлнэ гэвэл дайчдаас чинь нэлээн цөөрнө шүү.

Эомер хэсэгхэн дуугүй байснаа тэргүүнээ өргөж.

- Бид хоёр хоёулаа яарах хэрэгтэй, миний морьд ч удаан зогслоо, чиний найдвар ч улам бүдгэрлээ. Би шийдвэрээ гаргалаа. Явах замаараа яв, харин би... Би чамд морьд өгье. Нэг зүйлийг гуйя. Чи зорьсноо биелүүлсэн ч бай, хий дэмий тэнэсэн ч бай хамаагүй, морьд Онтавагийн цаадах Медусельдэд буцаж очсон байх ёстой, тэнд одоо Эдорасын өндөр цамхагт Теоден байгаа. Би чиний талаар алдаагүй юм байна гэдгийг Теоденд зөвхөн ингэж л ойлгуулна. Би чамайг батлан дааж байгааг чи харж байна, хэрэг болбол амиараа даана. Намайг битгий хөөдөөрэй.

- Хөөдөхгүй ээ.

Эомер сул морьдоосоо харийн гуравт өгөхийг тушаахад морьт дайчид мэл гайхаж, бие рүүгээ баргар царайлан харав. Ганцхан Эотан л зориглож чангахан дуугарав.

- За яахав, Гондорын баатар ванд итгэе, тэр одоо моринд мордох цаг нь болсон хүмүүсийн нэг, гэвч Ристанийн морин дээр гном мордоно гэдэг ёстой үзэгдэж, дуулдаагүй юм мөн биз? – гэж тэр хэлэхэд Гимли.

- Үнэхээр үзэгдэж дуулдаагүй юм – та нар тийм юм үзэхгүй, дуулахгүй гэдэгтээ итгэлтэй байж болно. Амьдралдаа би ийм том амьтны нуруу өөд авирахгүй. Хэрэг боллоо гэхэд би мориноос хоцрохгүй давхина – гэлээ.

- Хоцорно оо, бидэнд саатах цаг байхгүй – гэж Арагорн хэлэв.

- Миний араар сундалдчих, Гимли, найз минь - хэмээн Леголас түүнийг уриад. - Нээрэн ч тийм шүү. Чамд морь хэрэггүй, моринд чи бүр ч хэрэггүй - гэв.

Арагорнд том саарал морь ногдож, тэр үсрэн мордлоо.

- Нэрийг нь Хазуфел гэдэг юм шүү - гэж Эомер морийг нь танилцуулаад. - Шавдуулах хэрэггүй өөрөө яаж явахаа мэднэ, талийгаач эзэн Гарульф нь чамайг өршөөж туслах болтугай!

Леголаст Арод нэртэй хөнгөн, цолгион морь таарчээ. Леголас түүний эмээл хазаарыг авчих гэж дайчдаас хүсэв.

- Надад эмээл ч хэрэггүй, жолоо ч хэрэггүй – гэж тэр хэлээд морин дээр хийсэх мэт хөнгөхөн үсрэн мордов. Морь нь бардам бөгөөд баяртайгаар шинэ эзнийхээ хөдөлгөөн бүрт захирагдаж байгааг хараад ристаничууд гайхаж хоцров. Эльфүүд адгуус мал хоёр хар хорын өчүүхэн ч мэдрэмжгүй учир бие биеэ шууд ойлгож байгаа нь энэ ажгуу. Гимлиг найзынх нь ард сундлуулахад тэр шууд л бүснээс нь зуурав. Сэм Скробид анх завин дээр гарахад ямар байсан, Гимлид яг л тийм тааламжгүй байлаа.

- Баяртай, эрлээ олоорой! – гэж Эомер тэдний хойноос хэлээд – хүрээд ирээрэй. Бидний илд нэгдэн гялалзах болтугай!

- Би ирнэ ээ – гэж Арагорн бат нот хэлэв.

- Намайг ч гэсэн хүлээж байгаарай, хатан хаан Галадриэлийн тухай хэн ч ингэж ярьдаггүй юм. Хэрэв өөр багш олдохгүй бол би л чамд хэл ярианы соёл зааж өгөхөөс – гэж Гимли хэллээ.

- Амьд явбал үзнэ биз дээ - гэж Эомер хариулаад. - Үнэхээр гайхалтай үйл явдлууд болж байгаа юм байна даа, байлдааны сүх барьсан гномоор хэл ярианы соёл заалгах нь байна шүү дээ. Гэвч одоогоор баяртай!

Ингээд тэд хоёр тийш салан давхицгаав. Ристанийн морьдтой энэ зэрэгцэх унаа үнэхээр үгүй ажээ. Гимли эргэж хараад Эомерийн дайчид тэртээ алсад могой мэт мушгиралдан тоос босгож байгааг үзэв.

Арагорн морины давхилт дунд мөр алдахгүйн тулд эргэж харсангүй, Хазуфелын дэлэнд наалдан газар шагайж явав. Төдөлгүй тэд Онтавын ойролцоо ирж, Эомерийн ярьсан зүүнээс ирсэн тусламжийн мөрийг харав.

Арагорн үсрэн бууж мөрийг шинжлээд дахин мордож зүүн тийш эргээд мориныхоо амыг татасхийн сайтар ажиглаж явлаа. Дараа нь ямар нэг юм ажигласан бололтой дахин явгалж, талхлагдсан газрыг нүдээрээ шинжлэн удаан алхав.

- Юу илэрхий вэ, тэр илэрхий байна, гэхдээ бага юм илэрхий байна – гэж тэр эцэст нь хэлээд - Морьт дайчид мөрнөөс жагсаалаар буцах замдаа бүх мөрийг баллаж орхижээ. Зүүн талын мөр шинээрээ, эргээд Андуин руу нэг ч хазайлгүй шууд явсан байна. Одоо бид удаан явж, замаас гажиж гарсан мөр байгаа эсэхийг тогтоох хэрэгтэй. Орхууд энд ирээд араас нь хөөж байгааг мэдсэн байна. Тиймээс олзныхныг оройтоогүй дээрээ хаа нэг тийш авч явахыг

оролдсон байж таарна - гэв.

Тэнгэр бага зэрэг бүрхэж эхэллээ. Зүүн талаас хүнд үүлс нүүж ирэв. Баруунаа ташиж байгаа нарыг үүлс халхалж, Фангорн наашилсаар, хажуу бэлийн ой улам харлан бараантаж байв. Зүүн тийшээ ч, баруун тийшээ ч мөр салсангүй, саарал өдтэй урт сум нэвт сүлбэсэн орхуудын хүүр замаар дүүрэн.

Тэднийг ойн чөлөөнд хүрч ирэхэд бүрэнхий болж байсан бөгөөд овоолон галдсан оршуулгын үнс нурамнаас угаа уугиж байв. Хажууд нь орхуудын хугархай илд жад, хагархай дуулга, бамбай зэрэг зэвсгүүдийн сэгийг овоолжээ. Тэндээс нэлээд зайтай голын эрэг дээр шинээр нямбайлан босгосон хиргисүүр, дээр нь арван таван жад хатгаастай байна.

Арагорн тулалдааны талбайг нэгжсээр явах хооронд нар шингэж, өтгөн манан татав. Харанхуй шөнө ямар ч мөр олдохгүй нь илэрхий боллоо.

- Ямар ч ашиггүй, биднийг Тол-Брандираас гарснаас хойш олон оньсого тохиолдсон ч хамгийн муу нь энэ байна. Манай хоббитуудын шатсан яс орхуудынхтай холилдсон бололтой. Хэрэв Фродо амьддаа ийм мэдээ сонсвол хэцүүхэн л байх байх даа, Уудам хөндийд байгаа тэр хөгшинд бүр ч хэцүү байх болно. Элронд тэднийг явуулахгүй гэсэн шүү дээ – гэж Гимли үглэнэ.

- Гэндальф явбал яваг гэж зөвшөөрсөн шүү дээ - гэж Леголас хэлэв.

- Гэндальф ч бас өөрөө яваад хамгийн түрүүнд үхсэн шүү дээ. Тэр энэ удаад алдаж тооцоолжээ.

- Гэндальф өөрийгөө үхлээс аврах юм уу, биднийг хамгаалах тооцоо хийгээгүй - гэж Арагорн хэлээд. - Энд амиа аврах тухай биш, юугаар ч төгслөө гэсэн, дуртай ч, дургүй ч ажлаа л яаж хийхээ тооцоолох ёстой байсан. За, ингээд унтацгаая, эндээс хаашаа ч явахгүй, өглөө заавал мөр хайх хэрэгтэй байна.

Цуст тулалдааны талбараас арай зайдуу, өнгөрсөн оны навчсаа бараг бүгдийг нь авч үлдсэн, бахим том мөчрүүдтэй модны ёроолд хоноглохоор буув. Мөчрүүд нь хөгшин хүний гар шиг тал талаас унжиж, шөнийн сэвэлзүүр салхинд навчис нь гашуудалтай шивэгнэлдэн байлаа.

Гимлийн бие агзасхийж, чичрүүдэс хүрэх шиг болов. Хүн бүр нэг нэг хөнжилтэй байлаа.

- Гал түлцгээе, аюултай л биз, тэр яадаг юм бэ. Орхууд дэнлүүний эрвээхэй шиг гүйлдээд ирвэл ирэг! – гэж тэр хэлэв.

- Хэрэв манай хоёр хөөрхий хоббит ойд төөрч яваа бол бас л хүрээд ирнэ – гэж Леголас дэмжлээ.

- Бид гал түлбэл орхуудаас ч өөр, манай хоббитуудаас ч өөр хэнийг ч даллаж магадгүй, бид урвагч Саруманы уулын замуудаас холгүй байна шүү дээ. Тэгээд ч Фангорны ойд мөчир ч хөндөж болохгүй гэж ярьдаг юм – гэж Арагорн анхааруулав.

- Мөн яриваа, мустанgrimчүүд өчигдөр маш том гал асаасан, тэд мөчир байтугай моддыг цавчсан байхыг хараа биз дээ. Ажлаа хийчихээд энд хоносон, юу ч болоогүй – гэж Гимли зөрөв.

- Нэгдүгээрт тэд олуулаа байсан, тэдэнд Фангорны уур юу ч биш. Тэд энд ховор ирдэг, ойн гүнд тэдэнд хийх юм байхгүй, харин бид ойн гүн рүү орох хэрэг ч гарч болно. Тиймээс болгоомжлоорой! Модонд бүү гар хүрээрэй! – гэж анхааруулав.

- Модонд гар хүрч яах юм бэ, морьтнууд өчигдөр тэдэнд хүрэхээрээ нэг болсон, эргэн тойронд хичнээн мөчир хөглөрч байна – гэж Гимли хэлээд мөчир цуглуулахаар явж, Арагорн аварга модны голыг түшин, хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй суув. Леголас ойн цоорхойд зогсоод алсын чимээг сонсч байгаа мэт харанхуй ой руу ширтэн зогсов.

Гном гал түлэхэд гурвуулаа илүү нүднээс галаа нуух мэт тойрон суув. Леголас дээш өлийж, тэднийг хамгаалж байгаа мөчрүүдийг харлаа.

- Хараач хөөе! – хэмээн тэр дуу алдаад. - Мод дулаанд баярлаж байна! – гэв.

Магадгүй, сүүдрүүдийн бүжиг тэднийг хуурсан ч байж болох юм. Гэвч гурвууланд нь доод талын том мөчрүүд гал руу бөхийж, дээд талын мөчрүүд нь галын дөлийг харж байгаа юм шиг санагдав.

Хатсан хүрэн навчнууд галын илчинд жаргалтай байгаа юм шиг бие биеэ дэрлэсэн харагдав.

Тэдэнд зориуд үзүүлж байгаа юм шиг үл мэдэх харанхуй ойн нууцлаг амьдрал гэнэт нүдний өмнө нээгдэв. Эцэст нь Леголас нам гүмийг эвдэж.

- Селербэрн биднийг Фангорны ойгоос болгоомжлоорой гэж хэлснийг санаж байна, Яагаад тэгсэн юм бол Арагорн, чи юу гэж бодож байна? Боромир ч бас. Тэр энэ ойн тухай ямар домог сонссон юм бол?

- Би ч өөрөө энэ тухай янз бүрийн юм зөндөө сонссон, гондорчуудаас ч, өөр бусад хүмүүсээс ч, гэхдээ Селербэрнийг анхааруулахаас өмнө тэр бүх яриаг мэдэхгүйн улмаас санаанаасаа зохиосон дэмий зүйл гэж боддог байсан юм. Би сая яг чамаас асуух гэж байсан юм. Ийм ярианд үнэний хувь бий юу гэж. Хэрэв ойн эльф үүнийг мэдэхгүй бол хүний ярианаас юу авах вэ дээ!

- Чи ертөнцөөр надаас илүү тэнэсэн, манай Бөглүүд ойд Фангорны тухай юу ч ярьдаггүй, харин онодримуудын тухай, танай хэлээр бол онтуудын тухай дуу дуулдаг юм. Тэд аль дивангарт энэ нутагт амьдарч байсан юм гэнэ лээ, Фангорн чинь эльфийн домгоос ч эртний газар шүү дээ.

- Тийм ээ, энэ бол балар эртний ой – Булшны хөндийн дэргэдэх Мөнхийн ой шиг эртний ой, тэгэхдээ энэ ой түүнээс арав дахин том. Энэ хоёр ой нэг үндэстэй гэж Элронд ярьж байсан. Анхдагч эриний аварга ойн бүрхүүлийн үлдэгдэл гэж. Тэр үед энэ дэлхийн ойд зах хязгаар гэж байгаагүй, анхдагч төрмөлийн амьтад тэр ойгоор тэнэж явсан, тэгэхэд хүмүүс хараахан

төрөөгүй байсан юм гэнэ лээ. Гэхдээ Фангорнд өөрийн нууц бий. Тэрийг нь мэдэхгүй юм даа.

- Би мэдэхийг ч хүсэхгүй байна, ойн нууц алдах вий гэж айсны хэрэггүй, тэр нууц нь надад ямар ч хэрэггүй - гэж Гимли хэлэв.

Хэн эхэлж харуулд гарах вэ гэж шоо хаятал Гимлид буув. Нөгөө хоёр нь хэвтэнгүүт нам унтсан боловч Арагорн.

- Гимли! Нэг ч мөчир цавчиж болохгүй гэдгийг бүү мартаарай, унанги мөчир авах гэж хол битгий яваарай. Гал унтарсан нь дээр шүү. Өчүүхэн төдий ч юм болбол намайг сэрээ! – гэж хэлж амжлаа.

Тэгээд тэр дороо нам унтав. Леголас хажууд нь унтаж байв. Хоёр гараа цээжин дээрээ зөрүүлж, нүдээ нээлттэй чигээрээ унтаж байхад зүүд, шөнийн хагас бодит байдал хоёр холилдоно. Эльфүүд ингэж унтдаг билээ. Гимли галын дэргэд бөгтийн суугаад сүхнийхээ ирийг бодлогошронгуй илж байв. Навчсын сэрчигнээн л нам гүмийн цорын ганц чимээ байлаа.

Гэнэт Гимли өндийж харвал галын алсын гэрэлд нэгэн бөгтөр өвгөн зогсч байв. Тэр урт нөмрөгөөр биеэ ороосон, таяг тулсан байх бөгөөд унжсан том хүрээтэй бүрх малгай нүүрийг нь халхалжээ. Гимли босон харайсан боловч гайхсандаа дуугарч чадсангүй, Саруманы саварт орчихлоо гэсэн бодол толгойд нь зурсхийв. Түүний огцом хөдөлгөөнөөр сэрсэн Арагорн, Леголас хоёр ч өндийж, шөнийн гийчинг ширтэж байв. Гийчин хөдөлгөөнгүй зогссоор.

- Айх хэрэггүй, ойртоод ир, өвөө минь – гэж Арагорн – түүнд хэлээд – даарсан бол галд дулаац – гэв.

Арагорн босч түүн рүү алхтал өвгөн зүгээр л газрын гав руу орсон мэт алга болчихов. Ойр хавьд тэр байсангүй, мань гурав цааш хайхаас болгоомжлов. Сар орж, гал дөнгөж цогшиж байв.

- Морьд! Манай морьд алга! – гэж Леголас гэнэт дуу алдав.

Морьд ор мөргүй алга болжээ. Тэд уяанаас алдуураад хаашаа ч юм давхиад алга болсон бололтой. Гурвуулаа шинэ аюулд цочирдож, дуугарах ч сөхөөгүй алмайран зогсов. Энэ нутгийн цорын ганц холбоотон болсон Ристанийн баатар вангууд холын холд давхин одсон, Фангорны ойн чөлөөний цаана хязгааргүй бөгөөд түгшүүрт тал бээр бээрээр алслан цэлийж байгаа. Хаа нэгтээ шөнийн харанхуйгаас морьд тургих, янцгаах шиг сонсогдоод эргэн тойрон нам гүм болж, хүйтэн салхи унтаа навчсыг сэрчигнүүлнэ.

- За одоо яая гэхэв, давхиад явчихлаа. Бид олж ч чадахгүй, гүйцэж ч чадахгүй – гэж Арагорн хэлээд - Хэрэв өөрсдөө эргэж ирэхгүй л бол байхгүй юманд байцаалт үгүй гэдэг л боллоо. Бид анх явган гарсан, хөл маань байна даа.

- Хөл гэнэ шүү! - хэмээн Гимли ядрангуй хэлээд. - Хөлөө хурдлуул гэвэл болж байна, надад

дургүйцэх юм алга, харин хөлөө ид гэвэл чадахгүй шүү - гээд галд мөчир нэмэв.

- Дөнгөж саяхан л чамайг морин дээр мордуулах гэж ятгах хэцүү байсан, зүгээр хө, удахгүй морьтой болно – гээд Леголас инээв.

- Одоо өнгөрсөөн, олдсон боломжийг алдчихлаа - гэж Гимли урамгүй дуугарав.

- Хэрэв та хоёр мэдэхийг хүсч байгаа бол энэ Саруман байсан, өөр хэн ч биш. Эомер юу гэж хэлснийг санаж байна уу? Юүдэнтэй нөмрөг хөдөрсөн тэнүүлч өвгөн болж явдаг. Тэгж л ярьсан даа. Нэг бол тэр морьдыг үргээж явуулсан, эсвэл хөөгөөд явсан, одоо яах ч аргагүй. Миний үгийг битгий мартаарай, олон гай тохиолдоно доо!

- Үгийг чинь мартахгүй, - гэж Арагорн амлаад. - Манай энэ өвгөн юүдэнгээр биш, бүрх малгайгаар гангарсан байна гэдгийг ч саная. Ямар ч байлаа гэсэн чиний зөв, одоо бид өдөр ч, шөнө ч амар заяа үзэхгүй. Одоо цаашдаа юу ч болдог байлаа гэсэн амрах хэрэгтэй. Гимли, чи унт. Би жаахан харуулдъя. Би жаахан бодох хэрэгтэй байна, дараа нь унтаж авна.

Шөнө их л удаан өнгөрөв. Леголас Арагорны халааг авч, Гимли Леголасын халааг авсны дараа үүр цайв. Өвгөн ч байдаггүй, морьд ч ирсэнгүй.

Бүлэг 3

Урукхай

Пин бүдэг бадаг, айдас дүүрэн зүүдлэв. Тэр өөрийнхөө сулхан дууг сонсч байна. Хаа нэгтээх харанхуй хонгилд “Фродо, Фродо!” гээд л дуудаад байх юм. Гэвч Фродо хаана ч алга, харанхуйгаас орхуудын ой гутам муухай нүүрнүүд дооглонгуй ярзайн инээж, урт хумстай сарвуунууд нь тал талаас сарвайж байна. Мерри хаачдаг байна аа?

Пин сэрэхэд нүүр рүү нь хүйт үлээв. Тэр дээш харан хэвтэж байлаа. Үдэш болж, тэнгэр харанхуйлж байв. Тэр хажуу тийшээ эргээд, зүүд бодит байдлаас долоон дор, бодит байдал зүүднээс хамаагүй аюултай болохыг ойлгов. Түүний гар хөлийг бөх гэгч нь хүлжээ. Хажууд нь Мерри хэвтэж байна, нүүр нь саарал, толгой нь цус болсон заваан бөсөөр боолттой. Эргэн тойронд орхууд суух нь сууж, зогсох нь зогсч байна. Тэд хичнээн ч олон юм, бүү мэд.

Пиний ангалзан өвдөж байгаа толгойд болсон явдал олигтой бууж өгсөнгүй, бодит байдал зүүд хоёр холилдоод бүр хэцүү.

- Аа тийм. Мерри бид хоёр ой дундуур чигээрээ гүйсэн. Хаашаа, яах гэж? Нэг л хачин. Бид хоёрыг Тэнэмэл дуудаж байсан. Харин бид хоёр гүйгээд л, гүйгээд л, хашгираад л байсан чинь бөөн орх руу яваад орчихсон. Тэд нар чимээ чагнаад зогсч байсан, бид хоёрыг харангуугаа дайрсан. Орилоон чарлаан, төгөл дотроос дахиад зөндөө орхууд гүйлдэн гарч ирсэн. Бид хоёр ч илдээ шүүрсэн. Гэвч орхууд яагаад ч юм тулалдахыг хүсэхгүй байсан, бөөнөөрөө дайраад л, гараас барьж авах гээд байсан, Мерри хэд хэдэн бахь шиг гарыг тас цавчсан. Ээ - дээ, манай Мерри ч лут юм аа!

Тэгтэл ойгоос Боромир гүйгээд гараад ирсэн. Тэгээд орхууд хүссэн ч, хүсээгүй ч байлдахаас өөр аргагүй болсон. Боромир тэднийг үзэгдэж харагдахгүй шахам тас тас хяргаад байсан, амьд үлдсэн орхууд байдаг хурдаараа зугтаасан. Боромир бид гурав олигтой холдож амжаагүй байтал лав зуу гаруй орхууд бүсэлж авсан. Асар том биетэй, илд, нум сумаар зэвсэглэсэн орхууд байсан. Сум мөндөр шиг асгарсан, тэгэхдээ зөвхөн Боромир руу шүү. Боромир том бүрээгээ үлээхэд ой тэр чигээрээ цуурайлан доргиж, дайснууд эхэндээ сандарч ухарсан. Гэвч цуурайнаас өөр хэн ч туслахаар ирээгүй, орхууд зориг орж, түрүүчийнхээсээ ч илүү галзууран дайрсан.

Цааш нь Пин яаж ч хичээгээд юу ч сэргээн санаж чадсангүй. Түүний санаж байгаа хамгийн сүүлчийн зураг бол Боромир мод налан зогсоод цээжнээсээ сум суга татан гаргаж байсан, тэгтэл харанхуйлаад явчихсан. “Толгой руу л нэг юмаар дэлссэн байх, хөөрхий Мерриг гайгүй шиг шархдуулсан байгаасай. Боромир яасан бол? Орхууд яагаад бид хоёрыг алаагүй юм бол? Ер нь бид одоо хаана байгаа, биднийг хааш нь чирээд байгаа юм бол?”

Асуулт хангалттай олон, хариулт нэг ч байдаггүй. Тэр даарч, хүч тамир нь барагджээ. “Гэндалф дэмий л бид хоёрыг явбал яваг гэж Элрондыг ятгаж дээ, миний хэрэг гэж юу байхав дээ. Тээр садаа, илүүдэл ачаа. Одоо ч гэсэн намайг хулгайлчихсан, би орхуудад тээр садаа, хэрэггүй ачаа болчихлоо. Тэнэмэл юм уу, хэн ч хамаагүй эднийг хөөж гүйцээд бид

хоёрыг чөлөөлдөг ч болоосой! Үгүй шүү, ямар ичмээр юм бэ! Тэдэнд бид хоёрыг аврахаас илүү чухал ажил байгаа шүү дээ. Өөрөө л хичээх хэрэгтэй!”

Пин хүлгийг жаахан суллах гэж оролдсон ч болдог юм биш. Хажууханд сууж байсан нэг орх хоолойгоо хоржигнуулан хөхрөөд, дэргэдэхдээ өөрсдийнхөө зэвүүн хэлээр нэг юм хэлэв.

- Өгч байгаа дээр амарч ав, чи муу одой! – гэж тэр дараа нь Пинд хандаж нийтийн хэлээр зандрав, тэр нь тэдний өөрсдийнх нь хэлнээс ч зэвүүн муухай сонсогдлоо.

- Өгч байгаа дээр амарч ав! Хөл шиг юмаа дэмий битгий модгонуулаад бай, бид удахгүй хүлгийг чинь тайлна. Хөлтэй төрсөндөө дараа нь харамсч ханатлаа уйлах болно оо чи, нус цус хоёрыг чинь цувуулаад өгнө дөө!

- Болдогсон бол одоо ч гэсэн чувуулмаал байна, үклээ гуйгаад байна уу ши – гэж өөр нэг орх нь нийтийн хэлээр хальт мулт занахчаа аядав.

- Ши миний галт шайхан дуулах байсан даа. Оох, муу өмкий кархк! гэснээ тэр Пиний нүүр рүү бөхийж, өмхий самхай үнэрээрээ утан, урт шар соёогоо ярзайлгав. Тэрний гарт иржгэр иртэй урт хар хутга байлаа.

- Шимээгүй кепт, тэхгүй бол тэчэхгүй чүү - хэмээн тэр шүднийхээ завсраар сийгүүллээ.

- Дакиад көдөлбөл тучаалыг жаахан мартна чүү, муушайн Иценгардууд – гэснээ өөрийнхөө хэлээр. - Углук у багронк ша пушдуг Саруман-глоб бубхош екай! – хэмээн шүдээ хавирч, шүлсээ савируулан баахан хараал урсгав.

Пин үнэхээр айж, хөдөлгөөнгүй хэвтэхэд хүлээтэй хөл гар нь тэсэхийн аргагүй өвдөж, нуруу руу нь хайрга шигдэж байлаа. Өвдөлтийг тэвчихийн тулд тэдний яриаг чагнав. Эргэн тойрон ам хумхилгүй шаагилдаж байна, орхууд угаасаа хэрэлдэж байгаа юм шиг ярьдаг боловч энд ямар нэг маргаан гарсан, тэр маргаан улам ширүүсч байгаа нь илэрхий байлаа.

Тэдний яриа Пинд бараг бүрэн ойлгомжтой байгаад тэр ихэд гайхав. Орхууд голдуу Дундад газрын нийтийн хэлээр ярьж байв. Тэгэхээр энд газар газраас ирсэн өөр өөр омгийн орхууд байгаа ажээ. Тэд бүгд өөр өөрийн хэлээр ярих юм бол мэдээж холион бантан болно. Цаашид хаашаа явах вэ, олзлогдогсдыг яах вэ гэсэн хойшлуулшгүй чухал асуудал хэлэлцээд санал нийлэхгүй байгаа бололтой.

- Аятайхан шиг алах ч цаг алга, тэнэхээрээ нэг боллоо, тоглох зав байдаггүй – гэж нэг нь гомдоллов.

- Өөр зам байхгүй, түргэхэн шиг алья, ерөөсөө одоо алаад хаячихья, тэгэх үү? Ингэж их яарч явахад эднийг чирч юугаа хийнэ. Орой ч боллоо, цаашаа гүйх хэрэгтэй шүү дээ.

- Тушаал бол тушаал – хэмээн нэг бүдүүн хоолой захирангуй дуугараад. - Одойчуудаас бусдыг бүгдийг нь ал. Одойчуудад хуруугаа ч хүргэж болохгүй. Амьдаар нь, аль болохоор хурдан авчир гэсэн тушаалтай. Юу нь ойлгомжгүй байна?

- Яагаад амьдаар нь аваачих нь ойлгомжгүй байна. Эднээр яах юм бэ? Тамлаж зугаагаа гаргах юм уу?

- Тийм биш ээ! Эдний аль нэг нь ямар нэг онцгой чухал юм мэдэж байгаа юм уу, ямар нэг эльхийн ид шидийн юм авч яваа, тэр нь дайнд саад болоод байгаа гэж би сонссон. Тэгээд л бүгдийг нь байцаах ёстой болоод амьдаараа хэрэгтэй байгаа юм.

- Тэгээд л болоо юу? Тэгвэл одоо нэгжээд олчихъё! Юу ч олдож мэднэ, бидэнд хэрэг болж ч мэднэ шүү дээ!

- Инээдтэй юм ярьж байна шүү та нар - гэж нэг зэвүүн дуу зөөлөвтөр хэлээд. - Аваачиж өгөхөөс өөр замгүй байх аа. Би олзлогдогсдыг тамлаж болохгүй, нэгжиж болохгүй гэсэн тушаалтай.

- Би ч гэсэн тийм тушаалтай - гэж бүдүүн дуут батлаад. - амьдаар нь, барихад ямар байсан, тэр чигээр нь авчир, юу ч хороож болохгүй гэж надад тушаасан.

- Бидэнд хэн ч тийм тушаал өгөөгүй! – гэж маргаан өдөөгчдийн нэг нь хэлээд – бид өөрсдийнхнийхөө өшөөг авч, алж хядахаар уулнаас бууж ирсэн, хөлөө цуцтал гүйлээ, одоо алахыг нь алчихаад буцахыг хүсч байна, тэгээд л гүйцээ.

- Та нар бага юм хүсч байна даа – гэж хариуд нь архирах мэт дуу хариулаад. - Би Углук. Би та нарын захирагч. Би та нарыг Изенгардад хамгийн дөт замаар хүргэнэ!

- Юу гэнэ ээ, Саруманд Бүгдийг үзэгч Нүд хүртэл зарлиг биш болоо юу? – хэмээн зэвүүн дуут асуугаад. - Бид буруу тийшээ гүйгээд байна. Лугбурзад биднийг хүлээж байгаа, бид мэдээ хүргэх ёстой.

- Их мөрнөөр яаж гатлах юм бэ? Гүүрээр гарч дөнгөхгүй, бид цөөднө – гэж нэг нь эсэргүүцэв.

- Би гатлаад л ирсэн юм даа. Зүүн эрэг дээр нь нисдэг баатрууд биднийг тэнд хүлээж ядаж байгаа – зэвүүн дуут хэлэв.

- Хүлээж л байна биз, чи тэдэнтэй нисээд л явна биз, олзлогдогчдыг Лугбурзад аваачиж өгөөд шан харамжаа авна биз, харин бид морьт харуулууд энд тэндгүй отоож байгаа энэ аюулт хязгаараар амь тавин зүтгэх болно. Үгүй дээ, бидний зам нийлэхгүй, энэ бол аюултай газар. Эргэн тойронд дээрэмчид, үймээн дэгдээгчид.

- Аа-ха, чи хамт явна гэж бодоо юу, - Муу үхдлүүд та нартай булш руу л хамтаа орно доо. Уулнаас бууж ирэнгүүтээ учир шалтгаан тоочиж эхлэв үү? Бид нар байгаагүй бол та нар хаана байх байсан бэ? Бид бол урукхай дайчид! Бид дайсны их том баатрыг алсан! Бид энэ хоёр одойг барьсан. Бид бол Цагаан далийн эзэн Саруман цэцний цэргүүд. Тэр бидэнд амттайхан хүний мах өгдөг юм. Бид бол Изенгардын элч нар, та нар биднийг дагаж энд ирсэн, эндээс бидний араас, бидний замаар явах болно. Би бол Углук, сонсов уу та нар? Би үгээ хэлсэн шүү.

- Олон юм хэллээ дээ чи, Углук – гэж зэвүүн дуут дооглонгуй хэлэв.

- Лугбурзийнхан Углукийн ухаантай толгой мөрөн дээрээ тогтох цаг дууслаа гэж шийднэ дээ. Дээрээс нь бас яагаад ийм юм болов? Саруманаас болоогүй биз? гэж асууна. Саруман гэж хэн юм бэ, юу боллоо гэж тэр ийм үхээрийн тэмдэг зураад байгаа юм бэ? Цагаан далийн эзэн гэв үү, чааваас даа! Тэд үнэнч элч Грышнак надаасаа асууна, Грышнак би хэлнэ. Саруман бол – адгийн үхдэл, тэр ч байтугай урвагч. Гэвч бүхнийг үзэгч нүд тэрнийг харж байгаа, ямар ч байсан тэрнийг зайлуулна.

- “Үхдэл” гэж энэ хэлэв үү? Хэнийг хэлж байгаа юм бэ? Биднийг үү? Сонсов уу, та нар, эд өөрсдөө хүний хүүр зулгаадаг. Одоо биднийг, бидний хүүрийг идэх гэж байгаа юм биш биз дээ?

Орхууд түрхрэн шуугилдаж, илд хангиналдаад явчихлаа. Пин болгоомжтой хөрвөөж эргэн тойрноо харах гэж оролдов. Харуулууд хоёр хоббитыг орхиод нөгөөдүүлтэйгээ хутгалдав. Бүрэнхийд асар том биет Углук бүртэлзэж, тэрний өөдөөс пагдгар, майга хөлтэй, лужир том цээжтэй, бараг газар хүрсэн урт гартай Грышнак сөрөн зогсчээ. Тэр хоёрыг тойрон арай бага биет гоблинууд арзганана. “Умардын орхууд байхаас зайлахгүй” - гэж Пин бодлоо. Тэд илд, урт хутгаа сугалсан боловч Углук руу дайрах эсэхээ шийдэж ядан байгаа бололтой. Углук нэг муухай хашгиртал хаанаас ч гараад ирснийг бүү мэд тэрний омгийн арваад орх пижигнэтэл гүйлдэн ирэв. Углук гэнэт ухасхийн харайж, огцомхон цавчилтаар хоёр ч гоблины толгойг тас цавчив. Грышнак харанхуй руу алга боллоо. Бусад нь ухарч, нэг нь Меррид тээглэж, тас түрүүлгээ харан тэрийж унав. Тэр азаар тээглэж унасан бололтой, амь нь аврагдлаа. Углукийнхан түүний дээгүүр харайн гарч, эсрэг талынхныгаа хайр найргүй цавчлаа. Шар соёот харуулыг бараг хоёр хэсэг хувааж, иржгэр иртэй урт хутга атгасан хүүр нь Пиний дээрээс дарж унав.

- Зэвсгээ орхи! Одоо болно! Баруун зүг рүү гүйцгээе, доош буугаад толгод руу чигээрээ, цаашаа ой хүртэл эргээр гүйцгээнэ. Өдөр шөнөгүй гүйнэ, ойлгов уу? – гэж Углук орилов.

“Тэг-тэг, өмхий хоншоор чамайг цаадуулыгаа цуглуулж, жагсааж байх хооронд бид аргаа бодно” – гэж Пин бодлоо. Үнэхээр ч бодох юм байлаа. Түрүүний урт хар хутганы ир мөрийг нь шүргээд гарт нь халтирсан байлаа. Алга нь нэл цус болсон ч хүйтэн төмрийн шүргэлт түүний ухаан санааг сэргээж, найдвар төрүүлжээ.

Орхууд хам хум жагсч байсан боловч умардынхны зарим нь дахин эсэргүүцэж, хоёрыг нь цавчиж унагасны дараа бусад нь захирагдав. Хараал зүхэл оволзож, хамаа замбараагүй юм болж байна. Пинийг тоож харсан хэн ч алга бололтой. Хөлийг нь шувт ороон хүлсэн боловч гарыг аз болоход ард нь биш урд нь, тэгэхдээ зөвхөн бугуйгаар нь хүлжээ. Чанга хүлсэн боловч хуруугаа хөдөлгөж болж байв. Тэр дээрээсээ унасан үхдлийг хөрвөөж унагаад, тэр амьсгаагаа дарж байгаад гарынхаа хүлээсийг урт хутганы хурц ирэнд үрж эхлэв. Хутга үхдлийн гарт бат атгаастай байлаа. Хүлээсийг тасалчихлаа! Тэгээд хоббитын заль ухаанаар тасархай хүлээсийг бугуйндаа өмнөх маягаар ороож орхив. Хэрэгтэй цагт сэгсрээд л хаячихна. Тэгээд томоотой нь аргагүй хэвгээд өгөв.

- Олзлогдогчдыг мөрөн дээрээ! Харин оролдож болохгүй шүү! Нэг нь ч гэсэн замд үхвэл

өөрсдөө араас нь үхнэ гэж мэдээрэй! – хэмээн Углук уухилна.

Лужир том орх Пинийг хүүдийтэй гурил шиг мөрөн дээрээ авч шидээд, “хүлээстэй” гарынх нь хоорондуур толгойгоо шургуулан, гар дээрээс нь атгаж аваад хөлийнхөө хурдаар гүйв. Пин нүдний булангаар хартал Мерри бас л өөр шиг нь үүрүүлсэн “давхиж” яваа харагдана. Орхын бахь мэт сарвуу Пиний гарыг үхсэн ч тавихааргүй атгасан тул хумс нь шигдэж байлаа. Пин нүдээ аньж дахин унтахыг оролдов.

Гэнэт түүнийг дахиад л чулуун дээр буулгав. Шөнө болж, нарийхан хавирган сар баруун тийш хөвж байна. Тэд нэгэн хавцлын ирмэг дээр ирж, урдаас бүдэг манан хөөрч байна. Хаа нэгтээ ус хоржигноно.

- Тагнуулчид эргэж ирлээ – гэж хажууханд хэн нэгэн хэлэв.

- Тэгээд юу харагдаж байна? - гэж Углук архирав.

- Юу ч харагдсангүй, нэг морьтон л баруун тийш зугтлаа. Урд талд хэн ч алга.

- Одоохондоо алга байдаг байж, дараа нь юу болох вэ? Мөн ч таарсан тагнуулчид юм даа! Яагаад тэрнийг харваж алаагүй юм бэ? Тэр түгшүүр зарлана, тэгээд новшийн муусайн адуучид өглөө болохоос өмнө биднийг зүйл дуусгана. Одоо өмнөхөөсөө хоёр дахин хурдан гүйх хэрэгтэй.

Пин дээр Углукийн хар сүүдэр унав.

- Бос чи! Миний цэргүүд чамайг дандаа үүрч явахгүй. Одоо зам уул руу бууна, өөрөө гүй, харин сайхан мэдээрэй чи! Хашгирах юм уу, зугтаах гэж оролдвол шөрмөсийг чинь сугална шүү. Амьд үлдсэндээ баярлахгүй л байх шүү.

Тэр хөлийн хүлээсийг нь тас огтлоод, Пинийг үснээс нь татан босгов. Пин хадуурт хяргуулсан өвс шиг дахин унахад тэр дахин үснээс нь татаж босгов. Орхууд архиралдан хөхрөлдөнө. Углук Пиний ам руу дашмагаа шургуулахад хоолой руу нь ямар нэг өмхий, гашуун шингэн урсан оров. Гэвч тэр дороо хөл нь чангарч, өвчин намдлаа.

- Нөгөөдөх нь хаа байна? - гэж Углук асуугаад Мерри рүү очиж, бөгс рүү нь өшиглөв. Мерри ёолоход тэр угз татан суулгаад, толгойн боолтыг нь авч, шархыг нь модон хайрцагтай зунгааралдсан хар юмнаас түрхэв. Мерри өвдсөндөө тийчлэн орилоход орхууд шүгэлдэж, исгэрэлдэн баясав.

- Эмчлүүлэх дургүй байна, өө муу хар тэнэг! – хэмээн хөхрөлдөж - Өөрт нь юу хэрэгтэй байгааг өөрөө мэддэггүй ээ! Дараа нь чамтай цагийг сайхан өнгөрөөнө өө!-гэцгээв.

Гэвч одоохондоо цагийг сайхан өнгөрөөх завгүй, дахиад л гүйх хэрэгтэй, тэгэхдээ олзны хоёрыг орхихгүйн тулд хурдад нь тааруулж гүйх тул цаг алдаж болохгүй байлаа. Углук Мерриг өөрийнхөөрөө эмчилж, нөгөөх муухай шингэнээ аманд нь цутгаад, хөлийн хүлээсийг нь огтолж, үснээс нь татан босголоо. Мерри унаагүй боловч найгасхийн зогсч байлаа. Царай нь

цонхийж, дух нь ярагдсан байлаа. Гэвч өвчин нь намджээ.

- Өө хөөрхий, Пин гуай, чи бас энд яваа юм уу! Бас л жаахан зугаалахаар шийдсэн юм биз дээ? Өглөөний хоол үзэгдэхгүй байх чинь. Чиний ор дэр чинь хаа байна? – гэж тэр хэл нь ээдэрсэн ч хөгжилтэй хэлэхэд Углук.

- Хагархайгаа хамхи! Хэлээ бүү булталзуул! Шүд чинь байгаа дээр хэлээ хаз! Бүгдийг ёсоор илтгэсний дараа бүхнийг зохицуулна.

Тавлаг ор дэр ч,

Тансаг хоол ч

Та хоёрыг хүлээж байгаа.

Өглөөний зоогон дээр

Өөрийнхөө ясыг мэрээрэй! – хэмээн даапаалав.

Нарийхан хавцлаар манант тал руу уруудав. Мерри, Пин хоёрын хооронд хориод орх гүйж байлаа. Эцэст нь хөл дор өвс шаржигнаж, хоббитуудын сэтгэл сэргээд ирэв.

- Чигээрээ гүйгээд! Баруун зүгийг барьж, ялимгүй хойт зүг рүү хазай! Лугдуш түрүүл, хэн ч бүү хоцор! – гэж Углук захирлаа.

- Нар гарахаар бид яах вэ? – гэж умардынхны нэг нь асуухад.

- Байдаг хурдаараа гүйнэ! Чи яана гэж бодоов? Өвсөн дээр суугаад өгөр царайтуудыг хүлээнэ гэж бодоо юу? - гэж Углук уурсав.

- Бид гэрэлтэйд гүйж чадахгүй шүү дээ!

- Миний захиргаанд мэдрэлгүй юм шиг гүйх болно - хэмээн Углук амлаад - Одойнууд минь тогтоож ав. Хэн эхэлж бүдэрсэн нь ичээндээ дахиж очихгүй гэдгийг цагаан далиар тангараглая. Арчаагүй ялгадас та нарыг миний толгой дээр хаячих юм даа – гэснээ - хөөе, хөгийн амьсгаанууд аа! Хөдлөөрэй, үүр цайхаас өмнө газар хорооё! – хэмээн захирав.

Орхууд босон харайж, араатан мэт гүйлдэв. Энэ бол цэргийн жагсаал биш, сүрэг араатан байлаа. Ямар ч замбараагүй гүйлдэж, бие биедээ тээглэн хараал тавьж байсан боловч, гайхалтай хурдан гүйж байв.

Хоёр хоббитод гурав гурван манаач тавьсан ба Пин сүргийн сүүлийг мушгиж байв. “Удаан ингэж гүйж чадахгүй, өглөөнөөс хойш дусал шүүдрийн ус ч амсаагүй” гэж тэр бодлоо. Нэг манаач сүлжмэл бургасан ташуур бэлэн барьж явсан ч одоохондоо түүнийг хэрэглэх шаардлага гарсангүй. Балга глоток өмхий бальзам одоо болтол хүч тамир нэмсээр байв. Толгой нь ч саруул ажиллаж байлаа.

Тэдний тасалданги мөрийг тонгойн харж, хойноос нь цуцахыг мэдэхгүй гүйсээр байгаа Тэнэмэлийн ширүүн царай яг бодитой юм шиг дахин дахин харагдсаар байв. Хэдийгээр тэр хамгийн их туршлагатай мөрч ч гэсэн энэ нялцгай шавар хөрсөн дээрээс яаж мөр ялгах вэ? Тахтай том том гутлын улаар баллагдсан Мерри бид хоёрын жижигхэн өнгөцхөн мөрийг яаж олж харах вэ?

Налуу хушуу тойроод тэд нэг бээр орчим гүйсний дараа зөөлөн саарал хөрстэй хонхорт орлоо. Манан татаж, тэнгэрт сарны ташуу гэрэл бүдэгрэв. Өмнө нь гүйж яваа орхуудын хар сүүдэр бүдэгрэн алга боллоо.

- Хөөе, эгнээгээ бариач - хэмээн араас Углук архирна.

Пинд гэнэт нэг санаа гялсхийхэд тэр дороо баруун тийш ухасхийж, манан руу ороод бүдрэн унаж, нойтон өвсөн дэр тэрийн хэвтэв.

- Зогсоод! – гэж Углук орилов.

Орхууд хутгалдан үймэлдэв. Пин босон харайгаад цаашаа гүйлээ. Гэвч араас нь орхуудын хүнд хөл пижигнэж, нэг нь хажуугаар өнгөрөн урд нь гарав.

“Аврагдах тухай бодохын ч хэрэггүй! Гол юмаа хийчихлээ. Би хуурай газар дээр дэвслэгдээгүй мөрөө үлдээчихлээ!” – гэж Пин өөртөө хэлэв.

Тэр хүлээстэй гараараа хүзүүнээсээ эльфийн товчин зүүлтийг тайлж аваад хаямагц түүнийг бахим сарвуутай урт гар барьж авлаа.

“Орой болтол энд хэвтэнэ биз, Ер нь хэрэггүй л хаялаа. Хэрэв манайхнаас хэн нэг нь аврагдсан бол Фродог хамгаалж л байгаа!” гэж тэр бодов.

Суран ташуур хөлийг нь улайссан төмрөөр хайрах мэт ороолгоход тэр хашгирав.

- Болж! – хэмээн амжиж ирсэн Углук орилоод – тэр дахиад их гүйх болно. Хоёр бөөс хоёулаа хөлөө сайн ажиллуулаг! Эдэнд тусал, гэхдээ хэтрүүлж болохгүй!.. – гэж тэр ташууртай орход хэлээд Пинд хандаж. - Дурсах юмтай болов уу? Энэ юу ч биш, надаас шангаа хүртэнэ ээ чи, хүртээж амжина, одоо гүйгээд!

Цаашаа яаж гүйснээ Пин ч, Мерри ч санадаггүй юм. Айдас хүрэм зүүд, аймшигт мэдрэмж холилдон нэгэн уйтгарт аймшиг болж, хаа нэгтээ тэртээ ар талд найдвар улам улам сулран бүрэлзэж байлаа. Гүйгээд л байлаа, гүйгээд л байлаа, орхуудын араас арайхийн гүйцэж, хамаг хүч барагдан, орхын ташуур харгис бөгөөд чадварлагаар тэр хоёрыг тууж байлаа.

Амьсгаа давхцаж, бүдэрч, унан тусан гүйсээр л байлаа. Босч чадахгүй болоход нь өргөж босгоод, үүрч гүйцгээнэ.

Орхуудын заваан шингэн ч бараг үйлчлэхээ болив. Пин дахиад л бүдэрч, хамраараа өвсрүү шаан унав. Урт хумст савар түүнийг шүүрэн өргөж, бас л шуудайтай юм шиг үүрэн гүйлээ. Хав харанхуй болов. Шөнө болсон юм уу, сохорсон юм уу, бүү мэд. “Ямар ялгаа байна” – гэж

тэр бодов.

Бүдүүлэг шуугилдаан болж байна. Орхууд амралт шаардаж байгаа бололтой. Углук сөөнгө хоолойгоор хашгичиж байна. Пин газарт унаад, огт хөдлөлгүй балар зүүдэнд умбав. Гэвч удалгүй бахим савар дахин барьж аваад сэгсчиж, унагаж босгосоор сэрээв. Нүдээ нээхэд үүр цайсан байв. Түүнийг өвсөн дунд шидэж орхилоо. Эргэн тойронд тушаал өгч хашгиралдана.

Пин сүүлчийн хүчээ шавхан үхэл рүү дагуулах цөхрөлтэй тэмцэлдэж байлаа. Толгой эргэж, хамаг бие халуу оргино. Дахиад л нөгөө шингэнээ уулгасан бололтой. Нэг орх түүн рүү бөхийж, зүсэм талх, хэсэг хатсан мах шидэв. Нэг захаасаа хөгцөрсөн хатуу талхыг Пин шүлсээрээ норгоод ховдоглон залгисан боловч маханд гар хүрсэнгүй. Тэр өлссөндөө гутлын ул идэхэд ч бэлэн байсан боловч орхын гараас мах идэж болохгүй, хэний ч мах юм бүү мэд гэж шийдэв.

Өндийж суугаад эргэн тойрноо харлаа. Мерри хажууханд нь түрүүлгээ харан хэвтэж байна. Тэд ширүүн урсгалт голын эрэг дээр байх бөгөөд өмнө нь уул хөндөлсөж, өглөө эртийн нарны туяа уулын оргилуудыг гялалзуулна. Уулын бэл нэлдээ жигдхэн бус ойгоор бүрхэгджээ.

Орхууд дахиад л урхиран орилолдож, улайран маргалдаж эхэллээ. Умардынхан яасан ч цаашаа изенгардчуудтай гүйхгүй гэж шийджээ. Зарим нь арагшаа өмнө зүг рүү зааж, зарим нь зүүн зүг рүү заацгаана.

- За за, боллоо! – гэж Углук хашгираад – Цаашаа би мэдье! Алж болохгүй гэж та нарт хэлсэн, орхивол орхи. Та нар ч хангалттай гүйлээ, бид нар ч та нараас дутахгүй гүйлээ, орхи орхи! Харин би харж хандья, тэд миний гараас хаашаа ч гарахгүй. Урукхай ажиллана чиг, байлдана чиг, сураагүй дасаагүй юм биш. Цайвар арьстнуудаас айж байгаа бол зугтацгаа! Тээр ой руу гүй! Хүрчихэж магадгүй, өөр та нарт гарах гарц байхгүй. За түргэл! Түргэл түргэл, нэг хоёр толгойг чинь тас цавчихаас өмнө гүйцгээ, уг нь хоёр гурван толгой өнхрүүлчихвэл ч сэргээд л явчихна даа!

Дахиад хэсэг хэрэлдэж, зодолдсоноо зуу гаруй орх тасарч, уулын зүг голын эрэг даган ум хумгүй арилж өгөв. Хоёр хоббитын дэргэд изенгардаас ирсэн эв нэгтэй, эвгүй царайтай жар далаад булиа чийрэг, хар царайтай орх, том том нум, богино өргөн илдээр зэвсэглэсэн, том биетэй, зориг зүрхтэй хэдэн арван умардын орх үлдэв.

- За, одоо ч Грышнактай нэгийгээ үзнэ дээ – гэж Углук зарласан боловч хамгийн зоригтой халз тулаанчид хүртэл өмнө зүг рүү эмээсэн царайтай эргэн харж байв.

- Мэдэж байна аа, мэдэж байна, хараал идсэн адуучид бидний үнэрийг авсан байна. Чамаас болон бусад тагнуулчдаас л болж байгаа юм. Та нарын чихийг огтолж хаях хэрэгтэй.

Хүлээж бай, тулалдаан биднийх болно, бид бол дайчид. Бид тэдний морьдын махыг иднэ, арай амттайхан өөр мах ч идэж магадгүй – хэмээн Углук архирав.

Пин эргэж харлаа. Зарим урукхайнууд яагаад өмнө зүг рүү хараад байгаа юм бол? Тэндээс сөөнгө уухилаан, зэрлэг орилоон сонсдож, Грышнак гараад ирэв, түүний араас адилхан майга

хөлтэй, өргөн цээжтэй, газар шүргэсэн урт гартай тавь орчим орх гүйж ирэв. Тэдний бамбай дээр хүрэн улаан нүд зуржээ. Угрук түүний өөдөөс тосов.

- Хүрээд ирлээ хөөе! – хэмээн тэр хөхөрснөө. - Арай шийдвэрээ өөрчилсөн юм биш биз дээ?

- Тушаалыг яаж биелүүлж байгааг чинь харахаар ирлээ. Олзлогдогчдод гар хүрч үү, үгүй юу шалгах гэсэн юм - хэмээн Грышнак доогтой хүржигнэв.

- Тийм гэж үү! Дэний юманд санаа зовж дээ. Би чамтай чамгүй яаж ийгээд дөнгөнө. Тушаалыг ч биелүүлнэ, олзлогдогчдод ч гар хүрэхгүй. Өөр юу хэрэгтэй вэ? Чи их л амьсгаатай байх чинь, юмаа мартчихаа юу?

- Нэг тэнэг новштой тооцоо хийхээ мартчихаж. Тэр өөрөө үхэл рүүгээ гүйгээд ирнэ, тэрэнтэй чанга дайчид үлдсэн, ямар ч хэрэггүй үхчихвэл харамсалтай. Тэгээд л тэдэнд туслахаар ирлээ.

- Их тусалдаг эд гараад ирлээ! - хэмээн Угрук хөхрөх аядаад - байлдахад туслах юм бол ч яахав, тийм биш бол Лугбурз руугаа гүй, биднийг цайвар царайтууд бүсэлж байна. Чиний нөгөө магтаад байсан нисдэг сүгнүүд чинь хаа байна? Нисдэг морийг нь дахиад харваад алчихсан уу? Чи тэднийгээ нааш нь дуудчихгүй юу, хэрэв нисдэг сүгнүүдийн тухай чиний яриа худлаа биш бол хэрэг болж мэднэ.

- Нисдэг сүг гэв үү чи - хэмээн Грышнак дагжисхийн чичирч, урт хэлээрээ уруулаа долоох нь энэ үг түүнийг булшны илжмэгээр даллан дуудаж байгаа мэт харагдана. - Дуугүй байсан чинь дээр байх шүү, Угрук, саарал мал минь, чиний хамгийн аймшигтай хар дарсан зүүдэнд чинь ч тийм юм үзэгдэхгүй. Нисдэг сүг гэнэ шүү! Юм бүхнийг нэвт хардаг юм шүү! Чи ингэж хэлснийхээ төлөө хөлөөрөө дүүжлүүлнэ дээ, үхдэл минь! Тэд бол Бүхнийг үзэгч нүдний цөцгий нь гэж чи мэдэх үү? Чамд нисдэг хөлөг өгөх юм гэнэ ээ, хүлээж бай. Их мөрний энэ талд тэд одоо үзэгдэх болоогүй, эрт байна. Харин дайн эхлэхээр чи хараарай л даа... гэхдээ тэдэнд өөр ажил байх болно

- Чи мөн ч их юм мэдэх юм аа, ухаантан минь! Энэ ч чамд хэрэг болохгүй дээ, яагаад ч хэрэг болохгүй. Лугбурзийнхан чиний толгойд арай илүү ухаан байна гэж бодох юм биш биз? Харин одоо чамайг хэл амаа билүүдэж байх хооронд бид – Урукхай нар, хүчирхэг Изенгардын элч нар их мөрнийг сэлж гарна! Хагархайгаараа ялаа барихаа больж үз! Цаад хэдэн шаараа жагсаа! Хулчгар муу хог шаарууд аль хэдийн ой руу зугтаасан. Тэдний араас гүй, тэртэй тэргүй чи өөрийнхөө чихийг хардаггүйтэйгээ адил их мөрнийг үзэхгүй. Гүйгээд марш, түргэл! Би та нараас хоцрохгүй.

Изенгардын орхууд дахиад л Пин, Мерри хоёрыг шүүрч аваад мөрөн дээрээ шидэв. Орхуудын хөл доор газар ёолох мэт дүнгэнэв. Хэдэн цаг дараалан нэг ч амсхийлгүй гүйлээ. Зөвхөн хоёр хоббитын “унаа”-г солихын тулд л хоромхон зуур зогсч байв. Тэд тийм хурдан гүйсэн үү, Грышнакт тусгай төлөвлөгөө байсан уу бүү мэд, изенгардынхан аажмаар мордорынхныг гүйцэж, бүхнийг үзэгч нүдний бүлэг ард хоцров. Умардынхныг гүйцэхэд тун бага зай үлдсэн, тэндээс цааш ой руу хэдхэн харайгаад л орох байв.

Үдэш болохын өмнөхөн углукчууд умардынхныг гүйцэв. Тэд нарны гэрэлд тун их ядарчээ. Хэдийгээр нар хүйтэн тэнгэрийн хаяа руу орж байсан ч тэд толгойгоо бөхийж, хэлээ унжуулан гүйж байлаа

- Хөөе, нуснууд аа! - хэмээн Изенгардын орхууд нижигнэтэл хөхрөлдөж. - Та нар нэгэнт өнгөрсөн. Цайвар царайтангууд одоо та нарыг гүйцэж ирээд зүйл дуусгана. Хараач, тэр ирж явна! – гэж хашгиралдав.

Гэвч энэ мөчид Грышнакийн цухалдан хилэгнэсэн бархираан тоглоом биш, шоглоом болж байгааг нотлов. Морьтнууд газар дороос юм шиг гарч ирээд, хар хурдаараа давхилдан айсуй. Тэд ихээ хол гарч ирсэн боловч маш хурдан урагшилж, элсэнд шигдээд гүйж чадахгүй байгаа залхуу шумбагчдыг тэнгисийн давалгаа нөмрөн ирж байгаа мэт эргэлтгүй наашилж байлаа.

Изенгардын орхууд гэнэт түрүүчийнхээсээ хоёр дахин хурдалж эхлэхэд Пин ихэд гайхав. Тэд түрүүлээд ой руу орчихож мэдэхээр болов. Бас нар Манант уулын цаагуур орон жаргаж, шөнийн сүүдэр нэн хурдан нөмрөн ирж байгааг ч харав. Мордорын орхууд ч толгойгоо өргөн, хурдаа нэмлээ. Ой харанхуйлан ойртсоор. Их ойн захын төглүүд өмнөөс зөрөн өнгөрч, зам уул өөд өгслөө. Улам эгцрэн өндөрсч байсан ч орхууд хурдаа хассангүй. Тэдний өмнө Углук орилон захирч, араас нь Грышнак бархирч, олигтойхон хурдлаад орхуудын хөл ямар байдгийг үзүүлээд өгөхийг уриална. “Ой руу гүйгээд орчихвол бүх юм өнгөрөө” - гэж Пин бодоод, бараг хүзүүгээ нугалах шахан эргэж харлаа. Нүдний буланд зүүн талаас морьтнууд орхуудтай аль хэдийн зэрэгцэж ирээд, тэгш өндөрлөгөөр давхиж байгаа нь харагдлаа. Шингэх нарны сүүлчийн туяанд тэдний дуулга, жадны үзүүр алтран гялалзаж, урт цагаан шаргал үс нь намиран хийсч байлаа. Морьтнууд орхуудыг бүсэлж аваад тал талаас мөрөн рүү шахаж эхлэв.

“Энд ямар хүмүүс амьдардаг билээ?” – гэж Пин санахыг хичээв. Хэрэв Уудам хөндийд байхдаа гадуур бага сэлгүүцэж, газрын зураг судалж байсан бол, ер нь эрдэм ухаанд суралцаж байсан бол...” хэмээн харамсав. Гэвч тэгэхэд тэр ямаршуу толгойгоор сэтгэж байлаа даа. Бэрх цаг ирэхэд Гэндальфгүй, Тэнэмэлгүйгээр, тэр ч байтугай Фродогүйгээр амиа аврахын төлөө өөрөө арга сэднэ чинээ санасангүй явжээ. Мустангримтэй холбоотойгоор түүнд зөвхөн Гэндальфын Аянга нэрт морь л эндхийн унага гэсэн шиг санагдаж байв.

“Орхуудаас тэд биднийг яаж ялгах бол? Тэд лав л хоббитуудын талаар нэг ч үг сонсоогүй байж таарна. Хорт муу орхуудыг нэгийг ч үлдээлгүй тонилговол сайхан л байна, гэвч тэдэнтэй хамт бид хоёрыг тонилгочихгүй бол бүр ч сайн юмсан!”

Тэр хоёрыг орхуудтай хамт хоромхон зуурт зүйл дуусгаад, дараа нь нэг дор овоолж байгаад шатаачих юу ч биш болоод байв.

Морины давхил дунд мэргэн харвадаг харваачид ар араасаа цувран ойртож ирээд байгаа мэргэн оночихоод буцаж холдоно. Орхууд байдаг хурдаараа гүйж байхдаа тэдэнтэй харвалдавч сум нь мориных нь тоосон дунд л бууж байв. Эцэст нь тэдний мэргэн сум Изенгардын орхууд дээр бууж, орхуудаас суманд оногдсон нь унаж эхэллээ. Нэг нь яг Пиний хамар дор унав.

Харуй бүрий болж байсан ч Ристанийн морьт дайчид тулааныг эхэлсэнгүй. Орхуудаас маш

олон нь тэдний суманд оногдсон боловч яаж ийгээд хоёр зуу гаруй нь үлджээ. Орхууд ойд хамгийн ойрхон уулан дээр гарсан ба ой хүртэл ердөө гурван зуу орчим сажин байсан боловч цааш явах зам байсангүй. Морьтнууд хүрээгээ хумьж эхлэв. Хорь гаруй орх Углукийн үгэнд оролгүй бүслэлтийг сэтлэхээр дайраад гурав нь эргэж ирэв.

- Бидний ажил нэг иймэрхүү л байна даа, сайхан урхинд орлоо! Зүгээр зүгээр, агуу Угрук биднийг урьдынхаа адилаар аваад гарна – гэж Грышнак хорон муухай инээв.

- Одойчуудыг газарт! - гэж Угрук Грышнакийн хор малталтыг сонсоогүй юм шиг захираад. - Лугдуш, чи хоёр цэргийн хамт харуулд гар. Цайвар царайт гичийнүүд орж ирээгүй цагт алж болохгүй, намайг амьд байхад бас алж болохгүй. Ойлгов уу? Дуугаргаж болохгүй, алдаж болохгүй. Хөлийг нь хүл!

Түүний сүүлчийн тушаалыг тун ч хорлонтой, хичээнгүй гүйцэтгэв. Гэвч Пин олзлогдсоноосоо хойш анх удаа Мерритэй зэрэгцэж хэвлээ. Орхууд бас л хашгирч хэрэлдэн, зэвсгээ хангинуулж эхлэхэд хоббитууд далимдуулан үг солилцохоор шийдэв.

- Миний тогоо ерөөсөө чанадаггүй (толгой ажилладаггүй), туйлдаж гүйцлээ, дахиад ямар ч тэнхэл алга. Аврагдлаа ч гэсэн хол мөлхөж чадахгүй нь – гэж Мерри шивнэлээ.

- Путлиб байгаа шүү дээ! Путлиб! Надад байгаа. Чамд ч гэсэн байгаа биз дээ? Эд нар нэгжээгүй, зэвсэг л авсан, өөр юу ч аваагүй.

- Миний халаасанд ч байсан шиг санагдаж байна. Бяцарчихсан л байх. Байлаа гээд ямар ялгаа байна? Би амаараа халаасаа ухаж чадахгүй юм чинь!

- Амаараа ухах хэрэггүй. Надад ... – гэтэл түүний хавирга руу хүчтэй өшиглөв. Хэрүүл зодоон зогсч, харуулууд байраа эзэлсэн ажээ.

Намуухан, хүйтэн шөнө болов. Орхуудын бөөгнөрсөн уулын эргэн тойронд Ристанийн харуулуудын түүдэг гал асч, улаан шаргал гэрэл хүрээлэв. Түүдэг галууд ойрхон байсан боловч морьтнууд үзэгдсэнгүй. Орхууд гал руу олон сум хий хоосон тавьсны эцэст Угрук дэмий сум үрэхээ зогсоохыг тушаав.

Морьтнууд бүрмөсөн алга болжээ. Дараа нь сар манан дундаас дуртай дургүй гарч ирэхэд, галын гэрэлд ганц нэг хүн гялс үзэгдээд алга болж байгаа нь харуулууд бололтой.

- Нар гарахыг хүлээж байна, үхдлүүд чинь, бид хүлээж яах юм бэ, дайрах уу? Угрук юу бодож байгаа юм бол доо, тэрний толгой нь хаанаа байгаа юм бол? – гэж харуулуудын нэг нь дуугартал.

- Миний толгойг хаанаа байна гэв үү чи? – хэмээн архираад Угрук харанхуйгаас гараад ирэв. - Би юу ч бодоогүй байгаа юм уу? Хог новшнууд юм даа та нар! Умардын шар гэдэстүүд, Лугбурзын гориллуудаас ялгаа алга. Тэднийг ямар дайчин гэдэг юм. Орь дуу тавиад л сүүлээ хавчаад зугтана. Энэ өмхий адуучингууд бидний аравг арвангурав ногдож байна. Ийм тэгш газарт бид тэднийг дийлэхгүй. Тэр муусайн шар гэдэст бөөсний үүрнүүд ганц юм чаддаг нь

харанхуйд хардаг. Тэглээ гээд нэмэргүй. Цайврууд ч гэсэн нүдээрээ харанхуй өрөмдөхдөө гарамгай, тэдэнд бас морь нь байна! Морьтойгоо нийлэхээрээ тэд шөнийн салхийг ч хардаг гэсэн. Гэхдээ тэд нэг юмыг мэдээгүй байгаа. Маухур шилдэг цэргүүдийн хамт ойгоор ирж байгаа. Одоохон хүрээд ирнэ.

Изенгардчуудыг Углюк ийнхүү сэргээж чадсан боловч бусад орхууд бас л уурлаж, үглэсэн хэвээрээ. Харуулууд нэмж гаргасан боловч тэд авралын харанхуйгаа мөрөөдөн хэвтээд өгөв. Удалгүй баруунаас нүүсэн бөөн хар үүл сарыг халхлахад тас харанхуй болж, доошоо харахад хөл үзэгдэхгүй болов. Түүдэг галуудын хоорондын харанхуй улам өтгөрлөө. Гэвч орхууд амарч чадсангүй. Уулын зүүн хажууд бөөн орилолдоон болсон нь зүгээр ч нэг орилолдоогүй ажээ. Морьгнууд явгалан мөлхөж ирээд, арваад орхын бодийг хөтөлчихөөд харанхуйд алга болсон байв. Углюк тийшээ ухасхийлээ.

Пин, Мерри хоёр өндийж суув. Харуулд гаргасан изенгардчууд ч тийшээ гүйжээ. Гэвч мань хоёр оргох тухай бодох эрт байжээ. Хоёуланг нь үсэрхэг том сарвуу заамдан авч угз татав. Тэр хоёр Грышнакийн асар том толгой, аймаар муухай нүүрийг харав. Түүний амнаас өмхий самхай ханх тавина. Хоёр хоббитыг нүүрээр нь нийлүүлэн нэг сарвугаараа базаад, нөгөө сарвугаараа тэмтрэн нэгжиж эхлэв. Арзгар ширүүн, хүйтэн савар арьсыг нь хуулах шахам нуруугаар нь тэмтрэхэд Пин чичирлээ.

- За яаж байна, одойнууд аа? - хэмээн Грышнак шивнэж - Ямаршуухан амарч байна даа? Тийм дээ, тийм, тав тух муутайхан л байна. Энд болохоор, сэлэм ташуур, тэнд болохоор хурц жаднууд. Бөөсөн чинээ юмнууд өөрийнхөө хэмжээнээс том бусдын хэрэгт оролцох хэрэггүй дээ, хэрэггүй.

Урт хумстай махир хуруунууд улам хурдлан тэмтэрсээр. Орхын нүд цагаан болтлоо улайссан төмөр шиг хорслын очоор улалзана.

Пин гэнэт дайсны санааг үнэрлэсэн мэт таав. “Грышнак бөгжний тухай мэддэг юм байна! Углукийг холдонгуут биднийг нэгжиж байна. Бөгж өөрт нь хэрэгтэй байх нь!” гэсэн бодол зурсхийв. Пиний зүрх айсандаа амаараа гарах шахаж байсан ч тэр шуналдаа улайрсан хорт адгууснаас яаж мултрахаа байдаг ухаанаа хөвчлөн сэтгэв.

- Дэмий эрж байна даа чи, чамд олдохгүй. Тийм амархан юм биш – гэж шивнэв.

- Олохгүй гэнэ ээ? – хэмээн Грышнак Пиний мөрнөөс базаад. - Юу олдохгүй гэж? Чи юун тухай яриад байна, мэлхий минь?

Пин жаахан хүлээж байгаад дөнгөж сонсогдох төдий аяархнаар.

- Хорлум, хорлум. Юуны ч тухай биш ээ, миний эрдэнэ минь – гэж шуухитнав. Грышнакийн сарвуу салгалан чичирч эхэллээ.

- Аха! Чи тэрний тухай юу аа? Аха! Их юм мэдэх дэ-эн-ндүү аа-юулттай, дэ-энн-ддүү.

- Дэндүүгээр барах уу - гэж Мерри, Пиний санааг ойлгонгуутаа шивнэв. - Аюултайгаар барах

уу, чамд бол бүү-үү-ррчч. Гэвч энэ бол чиний хэрэг. Зүгээр тэрнийг авахыг хүсч байна уу, үгүй юу? Шулуухан хэлчих, хэрэв хүсч байвал оронд нь юу өгөх юм бэ?

- Авах аа? Авах аа? – гэж Грышнак гайхсан мэт давтаад салганан - Оронд нь юу өгөх вэ гэж үү? Юу авах юм бэ?

- Юу байхав дээ - гэж Пин үг бүрээ зөөж тавих мэт удаанаар шивнэж - Чи харанхуйд хий дэмий тэмтрээд яах юм бэ? Цаг алга, төвөг их. Зүгээр л бид хоёрын хүлээсийг тайлчих, бид хоёр хэнд ч нэг ч үг цухуйлгахгүй.

- Золгүй цох хорхойнууд минь дээ, - хэмээн Грышнак шуухирч. - Та хоёрт байгаа юм бүхнийг, та хоёрын мэдэж байгаа юм бүхнийг цаг нь болохоор гэдэс дотрыг чинь эргүүлж байгаад авна!

Нэг юманд л харамсах болно. Байцаагчийг аргалах юм байхгүй болно. Ямар их халаглах бол, Одоохон халаглана даа! Хаашаа яарсан юм бэ? Яарах газар байхгүй шүү. Яагаад одоо болтол гэдэс дотрыг чинь уудлахгүй байгаа гэж бодож байна? Надад итгээрэй, би та хоёрыг өрөвдөж байгаа юм, Углук ч өрөвдөх ёсгүй.

- Юу үнэн бэ, тэр үнэн - гэж Мерри зөвшөөрөөд – зөвхөн ачаагаа чирээд л яваад байх болно. Тэгэхдээ ямар ч байсан чиний ичээ рүү чирэхгүй. Бид хоёрыг Изенгард руу чирнэ, том гоблин Грышнак асар том хамартайгаа үлдэнэ, харин тэрнийг Саруман авна. Хэрэв өөрийнхөө ашгийг бодож байгаа бол одоо л бод.

Грышнак эцэст нь бүр галзуурлаа. Ялангуяа Саруман гэсэн нэр түүнийг бүр ч галзууруулав. Шуугиан намдсан тул түүнд цаг байхгүй болж байв. Углук юм уу, түүний харуулууд хүрээд ирнэ.

- За хэлээрэй. Чамд байгаа юм уу? Эсвэл чамд уу?

- Хорлум, хорлум! – гэж Пин хариулав.

- Хөлийн хүлээс тайл! - гэж Мерри хариулав. Орхын сарвуу улам салганав.

- За яахав, дутуу хийсэн хархнууд минь! – хэмээн тэр шүдээ тачигнатал хавираад – хөлийн хүлээсийг чинь тайлах уу? Тэгснээс та нарыг гэдсээр чинь боож алсан нь дээр. Та нарын яр бүрийг нэгжиж чадахгүй гэж бодож байна уу? Нэгжинэ ээ! Хоёуланг чинь жижигхэн жижигхэн хэрчинэ! Хөл чинь ч хэрэг болохгүй, би хөлийг чинь хэн ч саад болохгүй газарт аваачна!

Тэр хоёр хоббитыг шүүрэн авч хоёр сугандаа хавчуулаад, амыг нь алгаараа дарж, мөрөндөө толгойгоо шигтгээд ухасхийн гүйв. Хурдан бөгөөд чимээгүй гүйсээр тэр орхуудын харуулуудын дундуур гүйн гарч, шөнийн харанхуйд уусан баруун тийш, ойгоос урсч байгаа гол руу гүйв. Өмнө нь ганц гал дүрэлзэн асч харагдана.

Хэсэг гүйснээ тэр зогсч, чимээ чагнан харанхуй руу ширтэв. Юу ч харагдахгүй, юу ч

сонсогдохгүй байлаа. Тэр бараг дундуураа нугаларах шахан тонгойж, удаан урагшилж байснаа сөхрөн суугаад дахин чимээ чагнаснаа өндийв. Аз туршин бүслэлтийг дайран сэтлэх мөч туллаа. Гэвч яг өмнөөс нь морьтой хүний бараан дүрс гараад ирэв. Морь янцгаан хойт хоёр хөл дэрээ цоройж, морьтон нэг юм товчхон хашгирлаа.

Грышнак хоббитуудыг дороо хийн газарт нам хэвтэв. Тэгээд сэлмээ сугаллаа. Тэр ямар ч гэсэн олзлогдогчдыг алахаар шийдсэн боловч энэ шийдвэр аминд нь хүрчээ. Сэлэм ханхийж, зүүн талд байсан түүдэг галын гэрэлд гялсхийв. Тийм мэргэн харвасан уу, хувь заяа сумыг чиглүүлсэн үү, сум түүний баруун гарыг нэвт сүлбэв. Тэр сэлмээ алдаж, дуу алдав. Морин туурай тачигнаж, Грышнак босон гүйнгүүт жад нисэн ирж түүнийг нэвт сүлбэлээ. Тэр нэгэнтээ мухай хашгираад түсхийн унаад амь нь тасрав.

Хоббитууд тэр чигтээ хэвтсээр байлаа. Өөр нэг морьтон нөхөртөө туслахаар ирэв. Тэр морь онцгой хараатай байсан уу, онцгой мэдрэмжтэй байсан уу, ямар ч гэсэн хоббитуудаас үргэсэнгүй, дээгүүр нь хөнгөхөн харайж гарахад эзэн нь эльф цувтай, үхтлээ айж газарт наалдсан хоёр жижиг амьтныг анзаарсангүй.

Эцэст нь Мерри аяархан хөдөлж шивнэв.

- Энэ ч яахав, ингээд өнгөрлөө, одоо яах болж байна?

Хариулт хүлээх хэрэг байсангүй. Орхууд Грышнакийн амь тавин хашгирахыг сонсчээ. Уулан дээр түүнээс хамаагүй их хашгиралдаан болов. Хоббитууд алга болсон, Углук ирээд буруут этгээдүүдийн толгойг их биеэс нь салгасан байж таарна. Гэтэл бас харуулуудын түүдэг галуудын цаанаас ой болон уулсын зүгээс хариу хашгиралдаан сонсдов.

Углук үнэн хэлж, удаан хүлээсэн Маухур шууд морьтнууд руу дайрав. Туурайн чимээ тэр хоёрын хажуугаар тачигнан өнгөрлөө. Ристаничууд уулыг хүрээлсэн бүслэлтээ хумьж, орхуудаас нэгийг ч гаргахгүй арга хэмжээ авсан ба дайран орж ирсэн шинэ орхууд руу зарим бүлгээ илгээв.

Мерри, Пин хоёр байлдааны талбарын гадна үлдлээ. Одоо тэдний оргох замд ямар ч саад байхгүй болов.

- Ээ чааваас, гар хөл хоёр минь чөлөөтэй байдаг ч болоосой. Тэгвэл ч бид хоёр аврагдлаа даа. Гэтэл би хүлээс рүү хүртэл тонгойж чадахгүй юм, хүрдэг сэн бол тас мэрэхгүй юу.

- Мэрэх хэрэг байхгүй ээ, Яах гэж? Би чамд миний гар чөлөөтэй гэж хэлэх гэж байсан юм. Зүгээр л хүлээстэй юм шиг харагдаж байгаа юм. Чи битгий хий дэмий бондогоноод бай, май, энэ путлиб ид.

Пин гараа суллаад, халаасаа ухав. Путлибууд бараг нунтаг болсон ч алга болсонгүй. Цаасандаа боолттой чигээрээ байлаа. Хоббитууд хоёр хоёр путлиб идэв. Гурав ч байсан юм уу, нунтагарсан болохоор сайн мэдсэнгүй. Түүний амт нь хэвээрээ, энхрий гэрэлт царайнууд, хөгжилтэй инээд, бараг мартагдсан тансаг зоогийг санагдуулав. Тэр хоёр хажууханд нь болж байгаа тулалдааны чимээг үл анхааран тухтай сууж байгаад, удаан, бодолдоо автан байж

идэв. Пин эхэлж дуугарав.

- Зугтах хэрэгтэй!

Зэвсэгтэй болох гэтэл дэргэд хэвтэж байгаа Грышнакийн сэлэм хүнд, махир учир гоблины хүүр рүү мөлхөн очиж, урт, хурц хутгыг нь авлаа. Тэр хутгаар хүлээснүүдийг агшин зуурт таслав.

- Явцгаая! – гэж тэр хэлээд - жаахан бүлээцээд босч явна. Харин одоохондоо юу ч гэсэн мөлхсөн нь дээр.

Тэгээд хоёулаа мөлхлөө. Чийглэг, зөөлөн байсан тул мөлхөхөд эвтэйхэн байв. Тэд харуулын галд нэлээд ойрхон өнгөрсөн тул голын эрэг хүртэл маш болгоомжтой мөлхөв. Доор, эгц эргийн ёроолоор гол шоржигнон урсч байна.

Тулалдааны чимээ намжжээ. Маухур болон түүний “цэргүүд” –ийг хиар цохисон юм уу, хөөгөөд явуулчихсан бололтой. Морьт дайчид дахиад анир чимээгүй харуул хамгаалалтаа сэргээв. Харуулууд удаан үүрэг гүйцэтгэсэнгүй. Шөнө өнгөрөв. Үүлгүй тэнгэрийн дорно хаяа гэгээрлээ.

- Бид хаа нэг газар нуугдах хэрэгтэй. Тэгэхгүй бол харчихна. Нэг бол мориор гишгүүлж хаячихаад дараа нь орх биш байна гэж мэдээд гайхна биз... – гэж Пин хэлээд босч, хөлөө дэвсэлж үзээд - төмөр утаснаас хатуу сур байна, гэхдээ хөл маань бага зэрэг амь орж байна. Гэлдрэх үү дээ? Чи яаж байна, Мерри?

Мерри хөл дээрээ босов.

- Болж байх шиг байна аа. Ээ дээ, энэ путлиб уу! Орхуудын эмтэй ч зүйрлэх аргагүй юм аа. Юугаар хийдэг юм бол?

- Юугаар хийдгийг нь мэдсэний хэрэггүй дээ. Балга ус ууя!

- Үгүй ээ, эндээс гол руу орж болохгүй, маш эгц өндөр эрэгтэй. Ой руу явъя, тэнд очиж байж больё.

Тэр хоёр эргийн дагуу зэрэгцэн алхав. Явах замдаа жинхэнэ хоббит зангаар сүүлийн өдрүүдийн сэтгэгдлээ хуваалцан хөөрөлдөж, хошин юм ярьж, бие биеэ цаашлуулж явлаа. Тэр хоёрыг хөндлөнгөөс харсан хэн ч гэсэн хөл дээрээ дөнгөн данган тогтож яваа, зайлшгүй тарчилгаан тамлалт, үхлээс гайхамшгаар амьд гарсан, одоо харийн зэлүүд хязгаарт хоёулахнаа, найдах хэн ч, юу ч байхгүй хаягдсан хоёр бяцхан хүн гэж хэлэхээргүй байв.

- Эрхэм ноён Молтогчин та нүүрээрээ шаварт унаж нэрээ баастсангүй шүү - гэж Мерри дүгнээд.

- Бильбогийн номонд чамд зориулсан бараг бүтэн бүлэг орох юм байна. Би боломж олдмогц түүнд чиний гавьяаг ярьж өгнө. Сайн байна, чи тэр үст дээрэмчний санааг сайн мэдэж, сайхан тоглосон доо. Хэн нэгэн чиний мөрийг олж, чиний зүүлт олдох болов уу, мэдэх

юмсан. Би өөрийнхөө зүүлтийг нүд шигээ нандигнаж явна. Харин чи гээчихсэн гэж бичсэн нь дээр байх. Тийм ээ, чамайг хамраа сөхөж, биеэ тоолгохгүйн тулд би сүүлээ шарвах болж дээ. Брендизайк агаагийн цаг ирэхэд харин нөгөөдөх чинь яг дэргэд байж байдаг байна шүү. Чиний наад толгой чинь нэг л биш байна даа, намайг хааш нь дагуулаад ирчихэв ээ?

- Уудам хөндийд байхдаа би чамаас арай цөөхөн хэрээ тоолсонд баярлалаа гэж хэл. Бид Онтава голын эргээр явж байна. Тээр тэнд манант нурууны өмнөд үзүүр байна, харин энэ бол Фангорн.

Үнэхээр тэр хоёрын өмнө баргар өргөн ой бараантаж харагдав. Шөнө үүрийн гэгээнээс зугтан харанхуй ойруу орж байх шиг санагдана.

- Урагшаа, аймшиггүй зоригт Брендизайк! Эсвэл ерөөсөө буцах уу? Ер нь биднийг Фангорн руу орох хэрэггүй гэж зөвлөсөн шүү дээ. Чиний эрдэмтэй толгой үүнийг мартчихсан уу?

- Мартаагүй, гэвч тулалдааны талбар руу орсноос ойн гүн рүү орсон нь дээр.

Тэрбээр олон мянган настай моддын доогуур түрүүлж орлоо. Аварга том мөчрүүд гарт хүрэх шахан бөхийж, навчис нь үүрийн салхинд үл мэдэг чичигнэн газарт хүрч байлаа. Хоббитууд ойн харанхуйгаас сэмхэн эргэж харлаа. Бүдэгхэн гэрэлд зогсч байгаа хоёр бяцхан дүрс Зэлүүд ойн захаас дэлхийн анхны үүрийн гэгээг гайхан харж байгаа эльфийн хүүхдүүд шиг харагдаж байв.

Их мөрний цаадтай, Хүрэн талын цаанаас үүрийн туяа уудам талыг гийгүүлэн туяарав. Дайчдын эвэр бүрээ тэр туяаг угтан нэгэн зэрэг хүнгэнэлээ. Ристанийн морьт дайчид дайралтад орлоо.

Хүйтэн агаарт морьдын янцгаах, олон хоолойгоор дуулах дуу Мерри, Пин хоёрт тод сонсогдож байв. Өглөөний нар газар дэлхий дээгүүр нэг захаасаа улайран гарч ирэв. Дорно талаас морьт дайчид байлдааны уриагаа цуурайтуулан дайрлаа, тэдний хуяг дуулга, илд жад нарны туяанд цусан улаан туяа татуулав. Орхууд орь дуу тавин бархиралдаж, тэдний өөдөөс үүл мэт сум нисгэн саадгаа хоосолж байлаа. Хэд хэдэн морьтон газар харуулдан унахыг хоббитууд харав. Гэвч морьтнууд эгнээгээ хумин орхуудын байгаа уулан дээгүүр хуй салхи мэт давхилдсанаа буцаад давхилаа. Амьд үлдсэн орхууд харсан зүг рүүгээ таран зугтаасан боловч тэдний өөдөөс илд жадаар угтав. Нэг жижиг отряд хар үзүүрт жадаараа хана мэт хамгаалан ой руу шургуу урагшилж байв. Тэд тавиад сажин зай туулахад л ой руу орох байв. Тэд замыг нь хаасан гурван морьтонг унагалаа.

- Чи бид хоёр дэндүү удаан харж байгаа юм биш үү - гэж Мерри хэлснээ. Хараач, Углук! Тэрэнтэй дахиж уулзахгүй юмсан!

Хоббитууд эргэж, ой руу эргэж ч харалгүй гүйлээ.

Тиймээс тулалдаан яаж төгссөнийг, Углук болон түүний дагуулуудыг Фангорны ойн яг захад морьтнууд гүйцэн бүсэлж аваад, Мустангримийн гурав дахь жанжин Эомер мориноос бууж, Углуктай халз тулалдан цавчиж хаяхыг хараагүй билээ. Үлдсэн хэдэн орхуудыг морьт дайчид

нэгийг ч алдалгүй гүйцэн тас хяргав.

Тэд тулаанд унасан нөхдөө оршуулж хиргисүүр босгоод, тойрон зогсч тэдний гавьяаг магтан дуулав. Дараа нь дайснуудын хүүрийг овоолон шатааж үнс болгон хийсгэв. Орхуудын довтолгоон үүгээр дууссан бөгөөд энэ тулааны тухай мэдээг Мордорт ч, Изенгардад ч хүргээгүй боловч их галын утаа тэнгэрт хөөрч, түүнийг нэг бус үл анигч нүд харсан бөлгөө.

Бүлэг 4

Модон

Тэр хооронд хоёр хоббит намуухан урсгалт голын ойролцоох харанхуй ойгоор уулын баруун хажуу өөд ямар ч баримжаагүй мөртөө яаран өгссөөр Фангорны бөглүүд ойн гүн рүү улам л лав орж байлаа. Тийм ч аймшигтай биш болж, яарах ямар ч хэрэггүй байлаа. Гэвч амьсгаа улам давчдаж, агаар дутагдаж байгаа юм шиг болов.

Эцэст нь цааш явах ямар ч сонирхолгүй болов.

- Гүйцээ, цаашаа явах чадал алга, балга агаар байдаг ч болоосой – гэж тэр арай ядан хэлэв.

- Ядаж ус балгая, тэгэхгүй бол хоолой бүр хатчихлаа – гэж Пин хэлэв.

Тэгээд бүдүүн тахир үндэс даган гулгаж гол руу буугаад, алгаараа ус утгаж уув. Тунгалаг, хүйтэн ус ханатлаа уулаа. Мерри хажууд нь ирж суугаад бас ус залгилав. Ус уусны дараа бие нь тавиран сэргэж, санаа сэтгэл ч өөдрөг болов. Тэр хоёр эрэг дээр сууж, зовлон үзсэн хөлөө голын усаар угаан, тэнгэр өөд эгнээ эгнээгээрээ сүндэрлэсэн моддыг ажиглаж хэсэг байзнав.

- Одоохондоо төөрч амжаагүй биз дээ? – гэж Пин аварга мод налан суунгаа асуугаад – төөрсөн юм шиг байвал голын урсгал даган буцаж анх ой руу орсон газраа очъё - гэв.

- Тэгж болно л доо, харин хөл найдвар муутай байна, дээр нь бас амьсгалах агаар алга.

- Тийм ээ, энд бүрэнхийдүү, бас жаахан зэлүүд юм. Надад Молтогчингуудын хуучны ичээний орхигдсон өрөөнүүд санагдаж байна. Ордон шиг л ордон, даанч зөнд нь орхичихсон, тавилгыг нь нэг ч удаа өөрчилж байгаагүй, анх тавьсан чигээрээ л байсан. Тэнд хөгшин Молтогчин амьдардаг байсан, амьдраад л байсан, амьдраад л байсан, ордонтойгоо хамт зөнөөд тэндээ нас барсан, тэрнээс хойш зуун жил тийшээ хэн ч ороогүй гэж ярьдаг юм. Тэр хөгшин бол миний хуланц өвөө. Тэгэхлээр аль эртний юм байгаа биз дээ. Өчигдөр би тэр ордонг энэ ойтой адилхан болохыг мэдсэн юм. Чи зөвхөн энэ бутнуудыг л хар. Хаа сайгүй ургасан, бүгд хөгшин, урт цагаан сахлаа сэгсэрч байгаа юм шиг найгаад л. Модод нь ч гэсэн дээ, бүх навч нь хуурай, тэгсэн мөртөө хэзээ ч унаж байгаагүй юм шиг! Ерөнхийдөө огт өөрчлөгдөөгүй байна. Хавар энд ямар байдгийг ёстой мэдэхгүй юм.

- Гэхдээ нар бага ч гэсэн шагайдаг л юм байна, Бильбо Бөглүүд ойг тайлбарлан бичсэнийг санаж байна уу? Эндхийн ой түүнээс огт өөр юм байна. Тэнд бүх юм хар бараан, муухай, есөн жорын муухай амьтад орогносон байдаг. Энд бол бүрэнхий, аглаг зэлүүд. Ямар ч араатан амьтан байхгүй, яагаад гэвэл араатан амьтан амьдрах боломжгүй.

- Хоббитууд ч гэсэн амьдарч чадахгүй, жишээ нь би Фангорноор явах хүсэл даанч алга. Зуун бээр явна, идэх юм юу ч байхгүй, хүнсний нөөц юу билээ?

- Байх нь байгаа, гэхдээ даанч бага, бид нар халаасандаа нэг боодол путлиб хийчихээд л тэнэг

юм шиг гүйгээд байсан.

Тэр хоёр эльфийн пуглиб хичнээн үлдсэнийг шалгаж үзэхэд дөнгөж тав хоног хагас өлсгөлөн явахад л хүрэлцэхээр байв.

- Ядаж хөнжил байхгүй, өнөө шөнө бид хоёр хаашаа ч явлаа гэсэн хөлдөж үхнэ биз дээ – гээд Мерри санаа алдав.

- Хаашаа явахаа шийдэх хэрэгтэй, одоо бараг үүр цайж байгаа биз – гэж Пин хэлэв.

өмнөх ой гэнэт алтлаг туяагаар гийгүүлэгдэв. Хаа нэгтээгээс нарны туяа битүү ойг нэвтрэв бололтой.

- Ээ хөөрхий, чи бид хоёрыг энд мунгинаж байх хооронд нар аль эрт хөөрөөд үүлний цаагуур орсон юм байна. Тэгээд одоо үүлэн цоорхойгоор гийж байхгүй юу! Магадгүй их өндөрт хөөрсөн болохоор моддын навчсыг нэвглэн тусч байгаа биз. Тэр ташуу туяа тусч байгаа газар очиж харья!

Тэр газар нь тийм ч ойрхон биш учир хөөрхөн хөлөрч байж хүрэв. Уулын хажуу өмнөхөөсөө хэц болж, арай чулуурхаг байлаа. Нарны гэрэл улам тодорч, удалгүй тэдний өмнө хадархаг цохио гарч ирсэн нь нэг бол уулын нөгөө тал, эсвэл алсын уулсын үзүүр бололтой. Хажуугийн ой дулаацаж байгаа юм шиг навч мөчрөө дэлгэжээ. Дөнгөж саяхан бүх юм хар бараан байсан бол энд өтгөн хүрэн, хар толботой модны их бие араатны арьс мэт гялалзан сорлож үзэгдэв. Доохно талд шинээр ургаж байгаа ногооны өнгө газрын өнгийг сүлж, зүүдэндээ үзсэн юм шиг санагдана.

Тэр налуу хажуугаар бүдүүлэг хийсэн шат шиг жигд бус үеүд байх бөгөөд хадан хөрсийг он жилийн эргэлтэд салхиар боловсруулсан байгаль, цаг уурын бүтээгдэхүүн ажээ. Моддын оройтой бараг чацуу өндөр, захаараа хатуу өвсөөр бүрхэгдсэн өргөн цохио байх бөгөөд түүн дээр хоёрхон мухар мөчиртэй ганц мод байх нь наранд ээхээр гарч ирсэн хатангир туранхай хүн шиг харагдана.

- Дээшээ гаръя, агаараар амьсгалангаа эргэн тойрныг харъя – гэж Мерри хэлэв.

Мань хоёр халтирч гулгасаар чулуурхаг уул өөд өгслөө. Хэрэв энд үнэхээр шат хийсэн бол лав л тэр хоёрт зориулж хийгээгүй бололтой, урт хөлтэй, том алхдаг нөхдүүдэд л зориулсан бололтой. Тэр хоёр их яарч байсан учир шарх шалбархай, хөх няц болсон булдруу гүвдрүү нь өөрөө аяндаа эдгэрч, хүч тамир нь нэмэгдсэнийг анзаарсангүй. Эцэст нь мань хоёр нөгөө ганц өндөр модтой цохион дээр гараад, жаахан амьсгаа дарсныхаа дараа дорно зүг рүү харав. Моддын оройгоор баримжаалбал тэр хоёр ойгоор ердөө гурав дөрвөн бээр л явсан ажээ. Ойн чөлөөнөөс хар утаа олгойдож, тэдний араас хөөж байх мэт.

- Салхи чиглэлээ өөрчилж, дорноос үлээж байна. Хүйтэрч байна – гэж Мерри хэлэв.

- Тийм ээ, хүйтэн байна. Ер нь одоо ингэсхийгээд нар жаргаж, бүх юм дахиад саарал болно. Ямар харамсалтай юм бэ! Ойн үжирсэн өмсгөл наранд гялалзаж байна. Надад бүр таалагдаж байх шиг санагдаж байна.

- Ой энэ амьтдад таалагдаж байна гэнэ ээ, хөөе! – за наашаа эргээд хар даа, та хоёрыг урдаас чинь нэг хараадахъя, тэгэхгүй бол та хоёр надад огт таалагдахгүй байна шүү - гэж хэн нэгний дуу хоолой тэр хоёрын ард дуугараад - Тэгээд одоо та хоёрыг яах вэ гэдгээ бодож, хэлэлцье. Хурдан наашаа эргээд хар!

Хоббитуудын мөрөн дээр хуурай мөчир шиг хатуу гар бууж, эвтэйхэн бөгөөд захирангуйгаар базан эргүүлэв. Хэрэв тролл биш бол арвандөрвөн фут өндөр хүн зогсч байлаа. Түүний урт гонзгор толгой хатангир мөртөө бахим чийрэг биенээсээ шууд ургажээ. Түүний ногоон саарал өмсгөл модны холтостой адил өнгөтэй юм уу, эсвэл зүгээр л холтос юм уу, хэлэхэд бэрх, тэгсэн мөртөө гар дээр нь нэг ч үрчлээ, атираа байхгүй, гилгэр хүрэн арьстай ажээ. Хөл нь долоон хуруутай аж. Нүүр нь ердийн бус, урт дөрвөлжилсөн сахалтай, сахал нь эрүүнээсээ доош сахлаг бөгөөд өтгөн ажгуу.

Хоббитууд хамгийн түрүүнд тэдэн рүү удаанаар нэвт шувт ажиглаж байгаа нүдийг нь харав. Маш том, ногоовтор туяатай хүрэн нүд байлаа. “Пин хожим нь тэр нүдийг сэргээн санах гэж байн байн оролддог байв. Тоолж баршгүй олон эрин, урт удаан хугацааны тайван бөгөөд гүн бодлоор дүүрэн ёроолгүй худаг мэт, өнгөн дээгүүрээ өтгөн навчис юм уу, гүн нуурын нарийн иржгэр долгиныг наран гэрэлтүүлж байгаа юм шиг очис цацруулсан нүд байлаа. Юу ч гэмээр юм бэ дээ, газар дэлхий зөвхөн ой модоор хучигдаж, тэр нь одоо болтол нэг ч үндэс, нэг ч дэлбээг алгасалгүй ажиглан сэтгэн зүүрмэглэсээр дөнгөж сая сэрээд чамайг өнө эртнээс өөрийгөө ургуулж ирсэн шигээ чимээгүй бөгөөд яаралгүй харж байх шиг санагдсан” гэж Пин хожим нь бичиж билээ.

- Хррум, хуум, - хэмээн морин хийл шиг өтгөн баргил хоолой хүнгэнээд. - Гайхалтай, гайхалтай! Яараад яахав, яарах ямар ч хэрэггүй. Гэвч би та хоёрын дууг сонсохоос өмнө харсан бол жижиг орхууд л байна гэж бодоод шууд л няц гишгэх байсан, дараа нь харин харамсч барахгүй байсан биз. Та хоёрын дуу хоолой дажгүй юм аа, энхрий хонгорхон хоолой байна, надад бүр аль дивангарт улирч баларсан үеийг санагдуулсан шүү. Тийм ээ, та хоёр гайхамшигтай хүүхдүүд байна. Шууд хэлье, гайхамшигтай үндэс - мөчир байна.

Пин гайхсан хэвээрээ боловч айхаа гэнэт болилоо. Тэр нүд рүү харахад огт аймшигтай биш, харин ч их сонирхолтой байв.

- Асууж болох уу, та хэн бэ, нэрийг чинь хэн гэдэг юм бэ?

Гүн нүднээ залирхаг очис гялсхийв.

- Хррум, за байз, би хэн бэ гэдгээ чамд яаж шууд хэлье дээ. За за, би Онт байна, намайг тэгж нэрлэдэг юм. Тэгж л нэрлэдэг юм. Танай хэлээр бол Онт ч биш, Ерөнхий Онт. Зарим нь намайг Фангорн гэдэг, зарим нь Модон гэдэг. Ер нь Модон болог.

- Онт? - хэмээн Мерри гайхаж. - Энэ чинь юу гэсэн утгатай юм бэ? Чи өөрийгөө хэн гэж

нэрлэдэг вэ? Жинхэнэ нэрийг чинь хэн гэдэг юм бэ?

- У-у-у, их юм мэдэж авах нь хөөе! – гэж Модон хөгжилтэй хүнгэнээд – Их юм мэдвэл эрт хөгширдөг юм. Үгүй ээ, энэ талаар яараад хэрэггүй. Асуухаа азна, би асууна. Та хоёр над руу ирсэн болохоос би та хоёр руу очоогүй. Та нар хэн юм бэ? Үнэнээ хэлэхэд ухаан хүрэхгүй байна, залууст цээжлүүлдэг байсан эртний нэрийн жагсаалтаас та нарыг санахгүй байна. Гэвч энэ бол эртийн эрт байсан хэрэг, тэр цагаас хойш шинэ жагсаалт гаргасан ч байж магадгүй. Байзаарай хө! байзаарай! Юу гэдэг билээ дээ?

Эртний нэрийн жагсаалтыг сонсоорой!

Эхлээд би чөлөөт дөрвөн ардыг нэрлэе.

Эфирийн хүүхэд эльфүүд ертөнцөд анх мэндэлсэн;

Уулын гномууд дараа нь гантиг агуйд сэрсэн;

Удаад нь онтууд моддын сүрэгт ирсэн;

Ухаан, зоригт хүмүүн үхэлт тавиланг олсон

Хм, хм, хм-м-м...

Минж – сэргэлэн барилгачин,

Хонь - хурдан хөлт тийрэмтгий

Бодон – эрэмгий дайчин,

Баавгай - сахлаг-амтач,

Чоно - үргэлж өлсөнхий улинхай,

Туулай- гүймхий-аймхай...

Хм, хм-м-м...

Бүргэд - Өндрийн эзэн,

Бух гөрөөс - нугаар тэнэмхий,

Хэрээ – хар жигүүрт зарч,

Буга - титэм эвэрт,

Хун - лиш цэцэг мэт цагаан,

Могой - мөс мэт хүйтэн...

Ммм, хм-хм, хм-хм-хм, цааш нь юу билээ дээ? Тамтарарам-татам татам-тарарам-там-там. За за. Цааш нь юу байх нь чухал биш, жагсаалт урт, би санахгүй байна.

- Ингээд л бидний нэрийг эртний нэрийн жагсаалтаас болон домгоос хасаад байдаг юм – гэж Мерри гомдоллоод - Бид чинь гэрэлт хорвоод эхний өдрөө амьдарч байгаа биш шүү дээ. Бид бол хоббитууд.

- Жагсаалтад шууд оруулах хэрэгтэй! - гэж Пин санал гаргав. - Хоббит жижиг биетэй боловч сайн нүхний эзэн гэдэг ч юм уу, юу гэдэг юм, эхний дөрвийн дараа, үлэмж биет буюу хүмүүний дэргэд, тэгээд л болоо.

- Хм! Болохгүй нь юу байна, муугүй л бодож байна, огт муугүй! Тэгж шийдье, та нар чинь тэгээд нүхэнд амьдардаг юм уу? Сайн байна, сайн байна. М-да, хэн та нарыг хоббитууд гэж нэрлэдэг юм бэ? Эльфээр нэг л сонсогдож өгөхгүй байна, эртний бүх нэрийг эльфүүд өгсөн юм шүү дээ. Тэд л ийм заншил тогтоосон юм.

- Хэн ч биднийг хоббит гэж дууддаггүй, бид л өөрсдийгөө ингэж нэрлэдэг юм – гэж Пин хэлэв.

- У-гу-гу, а-га-га! За за! Мөн ч яарч дээ! Та нар өөрсдийгөө тэгж нэрлэдэг юм уу? Энэ нэрээ өөрсөд дундаа л хадгалж байхгүй, эхний тааралдсан этгээдэд л хэлээд тавьчихжээ. Ингээд л санамсаргүй өөртөө нэр өгчихөж л дээ.

- Нуугаад байх юу байна? – хэмээн Мерри инээгээд – Тиймдээ тулбал намайг Брендизайк гэдэг, Мериадок Брендизайк, гэхдээ ерөнхийдөө зүгээр л Мерри гэж дууддаг.

- Харин би бол Молтогчин, Перегрин Молтогчин, товчхоноор Пин гэдэг.

- Эге-ге, та нар бүгдээрээ дэндүү яаруучууд байна. Надад итгэсэнд чинь баярлалаа, гэхдээ та нар болгоомжтой байсан нь дээр шүү. Онтууд янз бүр байдаг, нэг үгээр хэлэхэд онт онтоосоо ялгаатай, зарим нь бүр онт ч биш, тэгсэн мөртөө хичнээн адилхан гээч. Хэрэв зөвшөөрвөл би та хоёрыг Мерри, Пин гэж дуудъя. Сайхан нэрүүд байна. Харин өөрийнхөө жинхэнэ нэрийг би одоохондоо хэлэхгүй, цаг нь болоогүй байхад хэлэх ямар хэрэг байна. Түүний нүдэнд бүхнийг мэдэгчийн учиртай инээмсэглэлийн оч гялсхийв.

- Миний нэр өдрөөс өдөрт нэмэгдсээр ирсэн, гэтэл би маш олон мянган жил амьдарсан болохоор энэ их урт яриа болно. Манай хэлээр, эртний онт хэл гээ л дээ, жинхэнэ нэрийг их удаан хэлдэг. Гайхамшигтай сайхан хэл, гэвч хэрэв нэг нь ярих хэрэгтэй, нөгөө нь сонсох хэрэгтэй бол их удаан ярих шаардлагатай болно. Хэрэв ярих хэрэггүй бол – гэснээ түүний нүдэнд дахин оч гялсхийж, хараа нь бага зэрэг нарийсаад. - Танайд одоо юу болж байна? Та нар энд яах гэж ирсэн юм бэ? Өөрсдийнхөө хэлээр хариул. Би эндээс бага сага юм хардаг, сонсдог, заримдаа үнэрлэдэг юм. Яахав дээ, эндээс, юу гэмээр юм бэ дээ... шууд хэлье.

- а-лалла-лалларумба-каманда-линд-ор-буруме дээрээс нь... Бүү замлээрэй. Энэ бол манай нэрийн өчүүхэн хэсэг нь, үүнийг бусад хэлээр юу гэж хэлдгийг би мартчихаж, нэг үгээр хэлэхэд одоо бид тэнд байна. Би сайхан өглөө болоход энд зогсоод нар яаж ээж байна, ойн

эргэн тойронд өвс ногоо яаж ургаж байна гэж боддог юм, адууны тухай, үүлний тухай, амьдрал яаж явж байгаа тухай боддог юм. Тэгээд юу гэж? Гэндальф энд ямар хамаатай юм бэ? Эсвэл энэ – бурарум – гээд морин хийлийн чавхдас тасрах шиг болсноо - Энэ орхууд, Изенгардад байгаа залуу Саруман гэж үү? Би мэдээ сонсох дуртай. Харин огт яаралгүй яриарай.

- Их том үйл явдлууд болж байна - гэж Мерри хэлээд. - Яаж ч хичээлээ гэсэн бид танд удаан илтгэх хэрэгтэй боллоо. Та биднийг битгий яаруулаарай. Үнэхээр ч яаралгүй ярьдаг юм билүү? Бүдүүлэг загналаа гэж бүү бодоорой, та биднийг яая гэж бодож байна? Ер нь та хэний талд вэ? Та Гэндальфыг таньдаг юм уу?

- Мэдээж, танилгүй яахав. Энэ шидтэн бол модны төлөө үнэнээсээ санаа тавьдаг цорын ганц шидтэн байгаа юм. Та нар бас таньдаг юм уу?

- Танихаар барах уу даа - гэж Пин гунигтай хариулаад. - Тэр бидний анд бөгөөд удирдагч байсан юм.

- Тэгвэл би та хоёрын бусад асуултад хариулъя. Та хоёрыг “яах” талаар би огт бодоогүй байна. Та хоёрыг гомдоох гэсэн үг үү? Үгүй дээ, яах гэж? Магадгүй, бид хамтдаа нэг үйл бүтээж чадах байх. Харин “сталууд”-ын тухайд бол, уучлаарай, огт ойлгохгүй байна. Би өөрийн, надаас өөр хэний ч биш талтай. Та нартай зам нийлбэл сайн л байна. Ингэхэд та хоёр Гэндальфын тухай яагаад тэр амьд байхгүй юм шиг ярив?

- Тэр амьд байхгүй. Цаашдаа амьдрах хэрэгтэй юм шиг санагдах юм, гэвч тэр одоо бидний дунд байхгүй – гэж Пин гунигтайяа хариулав.

- Ого-го, өө за за, Хум, хм, тийм юм биз дээ – гээд тэр дуугүй болж хоббитууд руу харснаа - Н-да, за уучлаарай, юу хэлэхээ мэдэхгүй байна. Ай даа, юу ч гэхэв дээ!

- Дэлгэрэнгүй сонсохыг хүсвэл бид чамд дэлгэрэнгүй ярьж өгнө өө - гэж Мерри амлав.

- Гэвч их цаг иднэ. Чи бид хоёрыг буулгачихгүй юу? Жаахан сууж, нар далд орохоос өмнө амжиж наранд эе, бид хоёрыг өргөсөөр байгаад ядраа биз дээ.

- Хм, ядрах гэнэ үү? Үгүй ээ, би ядраагүй. Би тийм юм бараг мэдэхгүй. Суух ч дургүй. Юу гэмээр юм бэ дээ, би бөхийх дургүй. Гэвч нар үнэхээр нуугдах гэж байна. Явцгаая эндээс, та нар юу гэсэн билээ?

- Уул гэж үү? – гэж Пин таамаглав.

- Цохионоос, шатнаас? - гэж Мерри хэлэв. Модон тэр хоёрын санал болгосон үгнүүдийг удаан бодов.

- Тийм ээ, уулнаас. Яг зөв. Ийм богинохон үгээр нэрлэдэг, гэтэл тэр энд үеийн үед байж л байдаг. За за, хэрэв та нарт ингэж нэрлэсэн нь ойлгомжтой бол яая гэхэв. Тэгвэл явцгаая.

- Хаашаа явах гэж?

- Манай гэр рүү, надад орон гэр хангалттай олон бий

- Эндээс хол уу?

- Тэрийг ёстой мэдэхгүй. Та нарынхаар бол хол байж мэдэх юм. Ямар ялгаа байна?

- Харж байгаа биз дээ, бид хоёр бараг нүцгэн болчихоод байна, идэх юм бараг байхгүй – гэж Мерри хэлээд уучлал гуйв.

- А! Хм! Зүгээр, энэ юу ч биш гэж Модон хэлээд – би та хоёрыг ургаж цэцэглэтэл умдаалж хооллоод өгнө. Хэрэв бидний зам салбал би та хоёрыг өөрийнхөө хязгаарын хаа дуртай газарт чинь хүрээд өгнө. За алив, явъя гэлээ.

Тэрбээр мань хоёрыг хоёр мөрөн дээрээ эвлэгхэн бөгөөд, багтай суулгаад, аварга том хөлөөрөө ганцхан алхахад цохионы ирмэгт хүрэв. Түүний хөлийн хуруу хадан хөрсөнд хатуу үндэс шиг шигдэн орж байлаа. Тэрбээр шатаар болгоомжтой, намбалаг алхсаар ойн гүн рүү цаашлав.

өргөн, жигдхэн алхаагаар, голоос холдолгүй шугуй дундуур алхлан ойт хажуу өөд өгслөө. Модод түүнийг үл анзаарна. Замаараа яв яв гэсэн шиг зүүрмэглэн байхад зарим нь түүнийг харангуут ихэд баярлан өмнөөс нь мөчрөө өргөж байлаа. Модон явдал дундаа тэдэнтэй болон өөртэйгээ байнга ярих бөгөөд удаан, уянгат аялгуу нь чихний хажуугаар урсан өнгөрнө.

Хоббитууд тэвчээр зааж, дуугүй байв. Тэр хоёр яагаад ч юм бүх юм их бага ямар нэг хэмжээгээр хэвийн байгаагийн дээр цаашид яах вэ гэдгээ сайтар бодмоор санагдаж байв. Пин эцэст нь тэссэнгүй.

- Модоон, хөөе Модон, - бага сага юм асууж болох уу? Жишээ нь, Селербэрн яагаад чиний ой руу орох гэсний хэрэггүй гэж зөвлөсөн юм бэ? Тэр бидэнд болгоомжтой бай, юу ч болоо билээ гэж хэлсэн юм.

- Н-да-а, тэр юу гэж хэлсэн гэнэ ээ? – хэмээн Модон дүнгэнэснээ. - би ч гэсэн тэгж хэлэх байсан. Манай эндээс хурдан зайл гэх байсан. Тийм ээ, тэгж хэлэх байсан. Хэрэв би түүний оронд байсан бол “та нар бага шиг төөр, Лаурелиндоренанагээс холуур яв!” гэх байсан. Эльфээр ингэж нэрлэдэг байсан юм. Одоо бол богинохон - Кветлориэн гэж нэрлэдэг. Танай хэлээр бол Алтан аялгуут хөндий гэдэг байсан, одоо бол ердөө л Зүүрмэглэгч цэцэг гэсэнтэй ойролцоо. Дэмий ч тэгж нэрлээгүй байх. Тэдний санаагаар бол тэр хязгаар улам л ургаж цэцэглээд байх ёстой, гэтэл улам л гандаж гундсаар байгаа юм. Ер нь тийм газар руу тэнэх хэрэггүй, та нар ч, өөр бусад нь ч тэр. Та нар тэндээс гараад ирсэн байна, яах гэж тийшээ очсоныг би одоохондоо мэдэхгүй байна, миний л мэдэхээр тийшээ орж байсан тохиолдол байхгүй. Тийм ээ, эвгүй хязгаар шүү.

Манай энэ хязгаар ч ялгаагүй. Хэрмэл, тэнэмэлүүдэд энд муу юм их тохиолдож байсан, муу юм гэж хэлэхээс өөр юу гэхэв дээ. М-да, манай эндээс зүгээр гараад явчихгүй шүү гэснээ. - Лаурелиндоренан линдолорендор малинорнелион орнемалин - гэж дургүй шинжтэй хэлэв.

- Тэд Кветлориэнд ороод цагаан гэгээ ч үздэггүй. Селербэрн бүр залуудаа тэнд шингэсэн, тэр цагаас хойш манайд, ер нь Алтан ойгоос гадуур их юм өөрчлөгдсөн. Гэвч Таурелиломеа-тумбалеморна Тумбалетауреа Ломеанор гэдэг үнэн шүү, яг л урьдынх шигээ байгаа юм. Тийм шүү, олон юм өөрчлөгдсөн, газар болгонд биш ч гэсэн байх газартаа урьдынхаараа байгаа юм бий.

- Чи юун тухай яриад байгаа юм бэ? Юу газар болгонд биш гэж? – Пин асуув.

- Мод, онт хоёр – гэж тэр хариулаад. Би өөрөө юу гээч болоод байгааг сайн ойлгодоггүй, ойлгомжтой тайлбарлаж ч чадахгүй байх. Гэхдээ оролдоод үзье. Жишээ нь бидний зарим нь онт байсан чигээрээ, жам ёсоороо амьдарч байна, бусад нь унтаад өгсөн, модожсон гэх юм уу даа. Харин модод бол өөр. Модод мод байсан чигээрээ л байна, зарим нь дахин сэргэж байна. Тийм мод маш олон. Зарим нь бүр бүрмөсөн сэрсэн. Тэдний дотор авч ч болохгүй, хаяж ч болохгүй онтууд бий л дээ, тэдний онт гэж юу байхав дээ. Тиймээ, байдал ийм л байна даа.

Жишээ нь мод байна. Юу ч болоогүй юм шиг ургаад л, ногоороод л байна. Гэтэл гол нь өмхөрсөн байдаг. Онтавагийн доод биеэр ургадаг байсан эртний бургасыг аваад үз. Одоо тэд оргүй алга болсон, миний ой тойнд л үлдсэн. Хаврын навч шиг намуухан, энгийн, зөөлөн, хөнгөн бургас байсан, дотроосоо өмхөрч арай ядан тогтож байгаад алга болсон. Гэтэл эсрэгээр, уулын бэл орчмоор самар шиг том цөмтэй, гаднаас нь харахад нүд булаах юм байхгүй. Тэр чигээрээ хор гэсэн үг. Тийм ээ, манай энд дэмий тэнэх маш аюултай. Манайд дүнсийсэн хар хонхрууд бий, байсан чигээрээ байж л байгаа.

- Умардын Мөнхийн ой шиг үү? - хэмээн Мерри айсан шинжтэй асуув.

- Тийм, тийм, тиймэрхүү, гэхдээ хамаагүй аюултай, харын хар. Тэр мэдээж, Их харанхуй умард газарт харвасан, тэндхийн талаар та хоёрт бас таагүй дурсамж хангалттай байгаа юм байна. Манай энд харанхуй бүр эхнээсээ л байсан, одоо тэр чигээрээ л байна, зарим мод надаас хөгшин. Бид яахав дээ, чадах бүхнээ л хийж байна. Харийнхныг хөөж байна, дэмий балай юмнуудыг оруулахгүй байна, зааж сургаж, мэргэн ухаан суулгаж байна, арчилж тордож байна.

Онтууд бид эрт цагаас мод маллагчаар томилогдсон юм. Одоо биднээс цөөхөн үлдсэн дээ. Хонь, хоньчин хоёр хоорондоо адилхан гэж ярьдаг, гэвч тийм хурдан адилхан болчихгүй, тэдний амьдрал богинохон. Харин онт мод хоёр бол адилхны амьд жишээ. Яагаад гэвэл олон зууны туршид хамт байсан, онтууд нэг ёсондоо эльфүүд гэсэн үг. Хүмүүс шиг сониуч биш, тэгсэн мөртөө хүмүүсийг бодвол бусдын амьдралыг хавьгүй сайн ойлгодог.

Гэхдээ хүмүүс бидэнд илүү ойр байдаг. Бид, юу гэж хэлмээр юм бэ дээ, эльфүүдээс илүү өөрчлөгдөмхий, дотроос нь төдийгүй гаднаас нь хардаг. Ерөнхийдөө эльфүүд ч, хүмүүс ч бидэнтэй эн зэрэгцэхгүй. Онтууд хөл дээрээ багтай явж, илүү алс хардаг юм.

Миний ойрын төрөл садангуудаас нэг нь бүрмөсөн модожсон, тэрний чих рүү бүрээ үлээсэн ч сонсохгүй, тэгсэн мөртөө өөрөө дандаа шивнэж ярьдаг. Гэтэл бас бөхийсөн мод байдаг. Тэдэнтэй бид ярилцдаг юм. Тэр яриаг мэдээж эльфүүд зохиосон. Эльфүүд модыг сэрээж, өөрийнхөө хэлийг зааж өгч, өөрсдөө модны хэлийг сурдаг байсан.

Эртний эльфүүд тийм хачин хүмүүс байсан юм. Янз бүрийн яриа зохиож, хэн бүхэнтэй юм бүхний тухай ярьдаг байсан юм. Дараа нь их харанхуй нөмрөхөд тэд Тэнгисийн цаад руу хөвж одсон, зарим нь алс хязгаарт амьдрах газраа олсон, тэгээд л эргэж ирэхгүй тэр эрин цагийн тухай дуунуудаа зохиосон юм. Тийм ээ, эргэж ирэхгүй эрин цаг. Тэр эрт цагт эндээс Сарны уул хүртэл нэлдээ ой байсан, манай энэ ой бол ердөө л түүний зүүн хэсэг.

Мөн ч сайхан цаг байж дээ! Би өдөр бүр ойгоор нааш цааш явж, дуугаа дуулдаг, ойт хөндий миний дууг цуурайгаар дамжуулдаг байсан юм. Тэр үеийн ой Кветлориэнтэй адилхан, гэхдээ өтгөн, хүчирхэг, залуу байсан. Агаар нь ёстой бүгчим байсан даа! Би долоо хоног зогсоод ханатлаа амьсгалж чадахгүй байснаа санаж байна.

Модон дуугүй болж, чимээгүй, том том алхаж байснаа дахин амандаа нэг юм ярьж явснаа яриа нь аялгуу болж, аялгуу нь үгтэй байсан учир хоббитууд эцэст нь тэдэнд зориулсан дуу болохыг мэдэж чих тавин сонсов.

Хавар цагаар би Тасаринены

Бургасан дундуур хэсч явлаа,

Хаврын амтат агаар Нантасарионыг

Бүрхэн сэнгэнэж байлаа.

Надад дэндүү сайхан байсан.

Зун цагаар би Оссириандад очиж байлаа.

Зургаан голын хөндийд

Гол горхи нь дуулж байсан.

Надад түүнээс илүү баяр байгаагүй ээ.

Намар цагаар би Недлоретад зочилж байлаа.

Намрын гоёл Неддор Таурыг чимж байсан.

Надад түүнээс үзэсгэлэнтэй нь тааралдаагүй ээ

Өвлийн хүйтэнтэй би Дортонионад учирч байлаа.

Өвлийн Тхон Ородын цаст оргилууд минь!

Надад түүнээс илүү цагаан үзэгдээгүй ээ.

Бурхны тэр бүтээлийг би хоолойн чадлаар дуулсан.

Эртний тэр газрууд одоо

Тэнгисийн ёроолд нуугдсан.

Энд надад Амбарон, Тауреморне

Аладоломэ үлдсэн.

Өөрийнхөө хязгаараар би хэсч явна,

Өөрийнхөө Фангорныг би эргэж явна.

Миний Тауреморналомэд

Үндэс бүхэн гүнээс гүн шигдээстэй

Улирч одсон он жилүүд

Унасан навчис шиг хураагаастай.

Дуу ингээд төгсөв. Модон дуугүй алхаж, эргэн тойронд өчүүхэн ч чимээ аниргүй.

Өдөр ч төгсөх тийшээ хандаж, моддын ёроолоор манан татав. Дээрээс бараан цохионууд сүглийж, тэд манант нурууны өмнөд үзүүр – аварга Метхедрасын ногоон бэлд хүрлээ. Өндөр уулсын горхинуудаас эх авсан Онтава гол өндөр дээрээс дуу шуугиан ихтэйгээр үсэрч харайх мэт бууж байв. Баруун талаар бүдэг бараан налуу уул үргэлжилжээ. Бүрхэг тэнгэртэй үргэлжлэн нэлийсэн тэр уулан дээр нэг ч мод байсангүй.

Модон уулын хажуу өөд алхаагаа бараг саалгүй өгсөхөд уул хоёр тийш салан зай тавьж өгч хоббитуудыг алмайруулав. Тэдний өмнөх замын хоёр талд хоёр өндөр мод хөдөлгөөнгүй номхон зогссон хаалгач мэт харагдана. Хаалга байсангүй, харин сүлжилдсэн мөчрүүд зам хааж байв. Хөгшин онт хүрч ирэхэд мөчрүүд салж, дээш болон, навчсаараа мэндчилэх мэт найгав. Навчис нь том том, мөнх ногоон мөртөө бараантан гялалзаж байлаа. Тэдний өмнө өргөн өвсөн зурвас нээгдсэн нь тавиад фут өндөр хадан хана бүхий ойн өргөөний шал ажээ. Ханын дагуу өтгөн навчит харуул модод хоёр эгнэн жагсчээ.

Өргөөний цаад талын хана нь дундаа нуман хаалга бүхий эгц хадан хясаа байв. Нуман хаалганы дэргэд асар шигүү модод ургасан бөгөөд мөчрүүд нь дээгүүрээ нийлэн тааз үүсгэжээ. Түүгээр зөвхөн өргөн зам л цааш нэвтэрсэн байв. Голоос нэгэн горхи тасарч, нуман хаалган дээрх эгц хясаан дээрээс асар өргөсөн тэлж, нимгэн мөнгөлөг хөшиг болон буужээ. Тэгээд модоор хүрээлэгдсэн чулуун сан руу орж түүнийг дүүргээд, нэг сувгаар гарч дахин горхи болоод гол руу нийлэхээр хажуу руу урсан оджээ.

- Кгм! За хүрээд ирлээ дээ! – гэж Модон өгүүлэв.

- Бид гурав онтын алхаагаар мянга долоон зуу алхлаа, та нарын хэмжүүрээр хэд болохыг би мэдэхгүй. Товчхон хэлэхэд бид Захын уулын гантиг агуйд ирээд байна. Энэ газрыг юу гэж

нэрлэдэг вэ? Хэрэв түүний нэрийн багахан хэсгийг танай хэлээр орчуулах юм бол Булагт гэх юм уу даа. Би энд ирэх их дуртай. Энд хононо оо.

Тэрбээр хоббитуудыг өвсөн хивсэн дээр буулгахад мань хоёр түүний араас цаад талын нуман хаалга руу гүйв. Араас нь (тэр хоёрын хувьд доороос нь) харахад Модон өвдгөө бараг нугалахгүй алхах бөгөөд өргөн хуруунууд нь газарт шигдэж, дараа нь тавхайгаараа бүтэн гишгэх ажээ.

Модон урсгал мөнгөлөг хөшигний дор зогсоод, гүнзгий гүнзгий амьсгал авснаа нэгэнтээ хүнгэнэтэл инээгээд дотогш орлоо. Тэнд том чулуун ширээ байсан боловч дэргэд нь ямар ч суудал алга. Булангаас харанхуй сүүдэр мөлхөнө. Модон ширээн дээр хоёр чулуун аягатай ус тавиад дээгүүр нь алгаараа нэг илэх шиг болоход нэг нь алтлаг өнгөөр, нөгөө нь хар ногоон өнгөөр туяарав. Өргөө гэрэлтэж, хана, тааз өөд алтлаг шаргал - ногоон туяа гийх нь зуны нар нялх ногоон навчсыг нэвт гийгүүлэх шиг болов. Хоббитууд эргэн тойрноо хартал, өргөөн доторх бүх мод гэрэлтэж байлаа. Эхлээд бүдэгхэн гэрэлтсэнээ улам тодорсоор навч болгон ногоон, алтан шаргал, зэсэн улаан туяа татаж, их бие нь болор адил тунгалаг чулуугаар хийсэн багана шиг санагдав.

- За, одоо ярилцацгаая, гэхдээ та хоёр юм уумаар байгаа биз дээ. Бас ядарсан ч байх. Зүгээр зүгээр, одоохон сэргээд явчихна!

Тэр нэг булан руу очиход тэнд нүсэр том тагтай өндөр өндөр модон гангууд харагдлаа. Нэг модон гангийн тагийг аваад, ховоогоор утгаж, гурван хул дүүргэв. Нэг нь аварга том, нөгөө хоёр нь жижиг ажээ.

- Онтуудын гэрт суудал байдаггүй. Тиймээс одоохондоо ширээн дээр суучих – гэж тэр хэлэв.

Тэгээд тэр хоёрыг хоёр гараараа зэрэг өргөн газраас дээш зургаан фут өндөр гантиг ширээн дээр суулгалаа. Мань хоёр ширээн дээр тухлаад, модгор хөлөө савчууланхан хултай умдааг шимсэн шигээ их л додигор байлаа.

Хултай умдаа нь амтаараа Онтава голын устай төстэй боловч түүнд ямар нэг тааж хэлэхийн аргагүй өөр нэг амт, үнэр байсан бөгөөд нэг балгахад л шөнийн сэрүүхэн салхи сэвэлзэж, алсын ой үнэртэх шиг боллоо. Анхилам сэнхийсэн урсгал хөлийн хуруунаас толгойтой үс хүртэл бүх биеэр тархаж байлаа. Нээрэн тэр хоёрын үс чим чим хөдлөн босч, ургаж, бүр буржийж байв. Модон нумын хаалганы гаднах усан сан руу очиж, хөлөө дүрж хэсэг байснаа эргэж ирээд том хултай умдаагаа нэг амьсгаагаар маш удаан, бараг төгсгөлгүй гэмээр удаан залгилаад, хоосон хулаа ширээн дээр тавьж.

- У-ух, а-ах, - хэмээн амьсгаагаа сая нэг гаргаж. - Гм, кгм, м-да-а, ярилцацгаая. Буугаад шалан дээр суучих, би жаахан хэвтье, тэгэхгүй бол уусан юм толгойд гарчихна, унтчихна – гэлээ.

Баруун хананд өвс, нарийн мөчир дэвссэн нэлээд өндөр маш урт ор байлаа. Модон тэр орон дээр бүсэлхийгээрээ бага зэрэг нугаран удаанаар бөхийж байж сая нэг хэвтэж аваад, хоёр гараа дэрлэн тухтай нь аргагүй тааз өөд харж, сонсоход бэлэн болов. Мерри, Пин хоёр түүний өмнө зузаан өвсөн бухал дээр суулаа.

- За яриад бай, харин битгий яараарай! – гэж Модон хэлэв.

Мань хоёр хоббит яриагаа бүр эхнээс нь, Норгордоос дөрвүүлээ гарснаас эхлэн ярилаа. Тэр хоёрын яриа жаахан замбараа муутай, бие биеийнхээ яриаг байн байн тасалж байснаас гадна Модон яриаг нь зогсоон урьд нь юу болсон, дараа нь яасан гэх мэтээр асуулт тавьж байв. Тэр хоёр бөгжний талаар нэг ч үг хэлсэнгүй, ямар зорилгоор аян замд гарсан, хаашаа зорьсноо ч хэлсэнгүй.

Модон юм бүхнийг маш их сонирхож, хар морьтнууд, Элронд, Уудам хөндий, Мөнхийн ой, Том Бомбадил, Мориин агуй, Кветлориэн болон түүний эзэн хатан Галадриэль нарын тухай байн байн асууж шалгааж байлаа. Хоббитан, Норгорд, ер нь өөрийн нутгийн талаар нэг бус удаа давтан ярихад хүрэв. Модон сонсч сонсч байснаа гэнэт асуув.

- Та нар тэндээ, кгм, онтуудыг..., биш ээ, онт биш, онтжингуудыг харсан уу?

- Онтжин гэнэ ээ? - хэмээн Пин гайхаж - Тэд чамтай адилхан уу?

- За ерөнхийдөө адилхан даа, кгм, гэхдээ адилгүй,... ямар байсныг нь мартаж орхиж ээ, тэдэнд бол танай хязгаар таалагдах байсан, тэгээд л асуусан юм л даа.

Тэрбээр Гэндалффын талаар онцгой их сонирхож, Саруман болон түүний ажил хэргийг бүр ч ихээр сонирхож байв. Хоббитууд бие бие рүүгээ хараад энэ талаар ийм бага мэдэж байгаадаа урам хугарав. Тэр хоёр Саруманы талаар зөвхөн Сэмийн ярьсан, их зөвлөл дээр сонссон зүйлс болон Гэндалфийн ярианаас л бага сага мэдэж байв. Нэг л юм сайн мэдэж байсан нь Угрук ба түүний цэргүүд Изенгардынх, тэдний эзэн бол Саруман гэж мэдэж байв.

- Гм, кгм! – хэмээн Модон тэдний яриа төгсгөлдөө орж, орхууд Ристанийн дайчдад хиар цохиулсан тухай уралдан ярьж байх үеэр дуугараад. - Н-да, та хоёр ч уул овоо шиг их сонинтой юм байна, ярих юм алга. Гэхдээ мэдэж байгаа бүгдийгээ ярьсангүй, маш олон юм орхигдууллаа, энэ мэдээж илэрхий байна. Гэндалф та нарт тэгж тушаасан юм байгаа биз дээ. Танай тэнд том үйлс бүтээгдэж байгаа юм байна, тийм ээ, их том үйлс, чухам ямар үйлс вэ гэдэг нь цагаа болохоор мэдэгдэнэ, оройтохгүй л байгаасай. Ээ дээ, үндэс мөчрүүд минь дээ, мөн сонин юм аа, нэрийн жагсаалтад ч ороогүй ардууд гараад ирдэг, тэгэхдээ бүр ямар ард гээч! Есөн бөгжтөн гэж хэн бэ гэдгийг аль дивангарт мартацгаачихсан, тэгсэн чинь харин нөгөөдүүл чинь багачуудын араас хөөж явдаг байх нь. Гэндалф яагаад ч юм багачуудыг алсын замд авч гарсан, Галадриэль тэднийг Карас-Галадхэнд зочилж тухлуулсан, орхууд тэднийг нүцгэн талаар мөшгөн хөөж байгаа, тиймээ, багачууд том тоглоомд татагдан орж дээ, одоо яая гэхэв, зөвхөн тэсээд л байхаас өөр замгүй.

- Чи хэний талд вэ? – гэж Мерри зориглон асуув.

- Кгм, гм, надад танай тэр агуу их дайн пад ч байхгүй – гэж Модон хариулаад - хүмүүс болон эльфүүд тэр асуудлаа чадлынхаа хэрээр зохицуулна биз, ид шидтэнгүүд бас ирээдүйн төлөө санаа зовж, ид шидээ үзүүлж, арга чаргаа барж байна. Надад ирээдүй хамаа байхгүй. Тэгээд ч надтай хэн ч алга, би ганцаараа байна. Ойлгож байна уу? Миний санаа зовох юм бол Ой, өнөөдөр хэн Ойн талаар санаа зовж байна? Эльфүүд санаа зовдог байсан, гэвч эльфүүд аль

эрт хуучных шигээ биш болсон. Гэлээ ч гэсэн хэнтэй ч хамаагүй хамтар гэвэл бид эльфүүдтэй л хамтарна. Тэд нэгэн цагт биднийг хэлгүй байхад хэлтэй болгосон, тийм юмыг мартаж болохгүй, бидэнд өөр өөр зам заяасан ч гэсэн бид бие биеэ мартаагүй. Тийм ээ, мэдээж хэрэг, би элдэв янзын хог новштой нэг замаар орохгүй, одоо энэ юу билээ дээ (тэр өөрийнхөө хэлээр “буларум” гэж ууртай хэлэв) мөнхийн дайсан орхууд, тэдний эзэдтэй яасан ч үгүй.

Тэд нар Бөглүүд ойг эзэгнэхэд би их санаа зовсон, дараа нь тэд Мордор руу алга болсноос хойш би тэднийг бодохоо больсон юм. Мэдээж, дорноос аймшгийн хар салхи үлээвэл ойгоос юу ч үлдэхгүй. Хөгшин онт юу хийж чадах юм бэ? Үхдэг юм уу, өөр ямар нэг арга хайдаг юм уу бүү мэд. Гэвч Саруман! Саруман манай хөрш. Энэнийг зүгээр орхиж болохгүй. Ямар нэг юм хийх хэрэгтэй. Би одоо Саруманыг яах вэ? гэж байнга бодож байна.

- Саруман гэж ер нь хэн юм бэ? – гэж Пин асуугаад. - Чи тэрний тухай олон юм мэдэх үү?

- Саруман бол шидтэн, шидтэн – тэгээд л болоо. Би тэр шидтэнүүдийн талаар тун бага юм мэднэ. Тэнгисийн цаанаас том хөлөг онгоцууд хөвж ирэхэд энэ шидтэнүүд гарч ирсэн юм. Тэр онгоцууд дээр сууж ирсэн юм уу, өөр газраас гараад ирсэн юм уу, бүү мэд. Саруман тэдэнд их хүндлэгддэг байсныг санаж байна. Эхэндээ тэр энд тэндгүй тэнэж, бусдын хэрэгт хошуу дүрдэг байсан. Эльфүүдийнхэд ч, хүмүүсийнхэд ч. Аль эрт тэрийгээ больчихоод, Ангреност, эльфээр Изенгард цайзыг үхэн хатан сонирхох болсон. Уг нь тун ч даруухан загнаж, Дундад газар даяар алдаршиж байсан юм. Тэрнийг Их гэгээн зөвлөлийн тэргүүнээр сонгосон гэж ярьцгаадаг, дэмий л сонгосон байх. Яг тэр үеэс л тэр муу муухай үйл рүү хазайж эхэлсэн гэж би боддог болсон. Гэхдээ тэр одоо болтол хөршүүдээ оролдоогүй байгаа. Манай хязгаараар зугаалж, надтай дэмий ярих дуртай байсан. Тэр урьд нь их эелдэг зантай байсан, бүх юман дээр надаас зөвшөөрөл гуйна, уулзахаараа миний яриаг их анхааралтай сонсдог байсан. Тэгэхэд би тэрний амьдралдаа ч үзээгүй олон юмыг ярьдаг байсан, тэр миний ярьсныг бусдад задруулдаггүй байсан. Нэг ч удаа ам алдаагүй. Тэгж байснаа гэнэт нэг л хачин болчихсон. Нүд нь яг л чулуун ханын хөшигтэй цонх шиг болчихсон, авч ч болдоггүй, хаяж ч болдоггүй (би тэрэнтэй аль эртнээс уулзахаа больсон шүү дээ). Одоо бол тэрэнд юу хэрэгтэй байсан нь надад ойлгомжтой болж байна. Тэрэнд эрх мэдэл хэрэгтэй байж, бүхнийг захирах эрх мэдэл, сүр хүч хэрэгтэй байж. Тэрнийг гаднаас нь харах юм бол юунд ч хэрэггүй болсон сүг байгаа, харин толгой дотор нь дандаа эрэг боолт байгаа. Ойлгомжтой, ойлгомжтой. Тэр мэдээж урвагч, өөр хэн ч биш. Юу гэсэн үг вэ? Орхуудтай орооцолдлоо, муу юм бүхний эх нь тэр болоод байна.

Бр-р-р, кгм! Энэ юу ч биш, энэнээс ч долоон дор юм хийгээд байна тэр. Хар шидийн хүчээр хамаг бузар булай юмыг хийж байна. Та хоёрын ярианаас үзэхэд Изенгардчууд зүгээр нэг орхууд биш, хүн төрөлт бузар үйлтнүүд юм шиг санагдаад байна. Их харанхуй эхэлснээс хойш муу орхууд мэтийн муу үйлтнүүд өдрийн гэгээ харж чаддаггүй байсан. Гэтэл Саруманы шинэ орхууд өдрийн гэрлийг үзэн яддаг ч гэсэн айхгүй байна. Тэр тэнд ямар гээч бузар юм хийчих нь энэ вэ? Хүмүүсийг орх болгосон уу, эсвэл орхуудыг хүншүүлсэн үү? Үүнээс бузар юм гэж юу байх вэ дээ!

Модон Саруманыг хэзээ ч сэхэшгүйгээр, газрын гүн дор ялзруулах онтын хараал хийж байгаа мэт хүрчигнэж, хуухирч хэсэг болов.

- Орхууд яагаад ийм зүрх зоригтой болж, гэгээн цагаан өдрөөр миний ой дундуур тэнээд байх болов гэж би их гайхсан юм. Сая бодоод үзсэн чинь Саруман аль эртнээс ойн бүх зөрөг жимийг судалж байсан байна, гэтэл би гэж тэнэг эндхийн бүх нууцыг нээгээд өгчихөж. Тэгээд л тэр одоо өөрийнхөө хог новшнуудтай энд эзэрхээд байгаа юм байна. Ойгоос үй олон мод унагасан. Сайхан ч модод, сайн ч модод байсан. Олон гуалин үлдээсэн, яахав шаазгайнууд баяртай байна, ихэнхийг нь Изенгард руу аваад явчихсан, тэндхийн пийшингүүдийг галлах гээд. Одоо Изенгард тэр чигээрээ өдөр шөнөгүй хар утаа олгойдуулж байна.

Саруманы Изенгард үндэснээсээ сүүлчийн мөчрөө хүртэл үжирч ялзрах болтугай! Би тэр цавчигдсан мододтой анд найзууд байсан юм, би тэднийг дөнгөж ургаж байхаас нь эхлээд мэддэг байсан юм, тэдний дуу хоолойг ч санаж байна, гэтэл одоо хэзээ ч, огтхон ч байгаагүй юм шиг бүгд алга байна. Дуучин шугуй байсан газарт амьгүй хожуул ёрдойж байна. Тийм ээ, би алдаа гаргасан байна. Хариуцсан ажлаа унагаасан байна. Одоо гүйцээ!

Модон ухасхийн босч, нуруугаа эгцэлснээ ширээн дээр нударгаараа шаав. Гэрэлт аяганууд чичирч, өнгөт очис хаялав. Модонгийн нүд ч ногоон очсоор цацарч, урт хууз сахал нь сагсар шүүр мэт босов.

- Үгүй шүү, хангалттай! – хэмээн тэр хүрхрээд. - Та хоёр ч гэсэн надтай хамт яв. Юугаар тусалж чадах вэ гэдгээ бод. Гэхдээ надад биш, найз нартаа тусал. Хэрэв дайсан урдаас ч, ардаас ч довтлох юм бол Ристанид байгаа, Гондорт байгаа найзууддаа тусал. Харин одоохондоо хамтдаа Изенгард руу явцгаая!

- Би чамтай хамт явна – гэж Мерри шууд зөвшөөрөөд - Тэгэхдээ чамд дараа болохгүйг хичээнэ

- Заавал явна - хэмээн Пин шүүрч аваад - Тэдний тэр цагаан дальтай заавал тооцоогоо бодно. Би танд хэрэг болохгүй байлаа ч гэсэн үүнийг заавал хийнэ. Углукийг би мартаггүй, бид хоёр яаж зугтсанаа ч мартаггүй.

- За тэгвэл битгий мартаарай! – гэж Модон хэлээд - Гэхдээ миний үг бачимдаж хэлсэн яаруу үг байсан шүү, яарах ямар ч хэрэггүй. Би жаахан цухалдсан байна. Эхлээд тайвширч, сайн бодох хэрэгтэй, тэгэхгүй бол “одоо боллоо, хангалттай” гэж хэлэх шиг амархан юм байхгүй. Заримд нь хангалттай байгаа, заримд нь хангалтгүй байгаа. Учрыг нь олно оо.

Тэр нуман хаалган доогуур орж, усан хөшгөн цаагуур зогслоо. Дараа нь инээж, биеэ нэг сэгсрээд, улаан, ногоон гэрэлт дусал цацруулан байв. Хэсэг бодсоноо орон дээрээ хэвтээд дуугүй болов.

Удалгүй тэр амандаа бувгнаж байгааг хоёр хоббит сонсов. Хуруугаараа тоолж байх шиг байлаа.

- Фангорн, Финглас, Фладриф, алга, ердөө л энэ үү, тийм дээ, бид цөөхүүлээ үлдлээ, энэ л хэцүү байна – гэснээ мань хоёрт хандаж. - их харанхуй алга болохоос өмнө хэсч явсан биднээс гуравхан нь үлджээ. Фангорн би, Финглас, Фладриф хоёр – энэ бол тэдний эльф нэр.

Хэрэв та хоёрт таалагдаж байвал Навчин, Үндсэн гэж нэрлэж болно. Ингээд бид гурваас Навчин, Үндсэн хоёр та нарт тус болохгүй. Навчин утгаад өгсөн, модорсон гэж хэлж болно. Бүхэл зунжингаа зогсоод л, бодоод л байдаг юм, бүр навчиндаа дарагдчихсан, өвдгөө хүртэл өвч ургуулсан. Өвөл болохоор хааяа нэг сэргэдэг байснаа одоо бүр больсон... Үндсэн Изенгардаас баруун тийших ойг сонирхдог байсан, тэр бол хамгийн найдваргүй газар гэдгийг хэлэх хэрэгтэй. Орхууд түүнийг шархдуулж, садан төрлийг нь хүйс тэмтэрсэн, хайртай моднуудаас нь нэг ч үлдээгүй. Тэгээд оргил тийшээ хайртай хуснууд руугаа очсон, тэндээс тэр бууж ирэхгүй. Гэхдээ би залуучуудыг татаж болох байх гэж бодож байна, харин тэдэнд ойлгомжтой тайлбарлаж, анхаарлыг нь татах хэрэгтэй, тэгэхгүй бол бид дээш өгсөхөд их бэрхтэй болж байна. Бид гарын арван хуруу хүрэлцэхээр цөөхөн болсон нь харамсалтай байна даа!

- Яагаад тийм цөөхөн гэж? Та нар чинь эндхийн эзэд шүү дээ. Олон нь нас барсан юм уу? – гэж Пин асуув.

- Үгүй ээ, та нарт юу гэж хэлмээр юм бэ дээ. Биднээс нэг нь ч өөрөө аяндаа үхээгүй. Энэ олон мянган жилд элдэв юм болж л байсан нь мэдээж, гэхдээ ихэнх нь модорсон. Угаасаа бид цөөхүүлээ байсан, нэмж огт төрөөгүй. Онтуухай, онтуужин нар аль эрт цагаас хойш төрөөгүй, танайхнаар бол хүүхэд юм даа. Манай онтуужин нар бүгд байхгүй болчихсон юм.

- Намайг уучлаарай, бүгдээрээ нэг ч үлдэлгүй үхчихсэн юм уу?

- Тэд үхээгүй! – гэж хэлэхдээ Модон бараг уурлах дөхөв. Би үхсэн гэж хэлээгүй, байхгүй болсон гэж хэлсэн. Хаашаа ч явсныг бүү мэд, алга болчихсон, бид яагаад ч олоогүй – гээд тэр санаа алдаж. Энэ тухай хэн бүхэн мэддэг гэж би бодож байсан юм, хичнээн ч дуу зохиолоо доо. Бөглүүд ойгоос Гондор хүртэл эльфүүд ч дуулдаг байсан, хүмүүс ч дуулдаг байсан. Онтууд, онтжингуудаа хайж байгаа тухай. Гэтэл одоо бүгдээрээ мартчихсан байдаг байжээ.

- Бид ерөөсөө юу ч мартаагүй, зүгээр л манай Хоббитанид уулсын цаадах дуу хүрээгүй юм байна. Чи юу болсон тухай шууд л дэлгэрэнгүй яриад өгчих, бас далимд нь дуулаад өгвөл сайн байна, алийг нь сайн санаж байна, тэрийгээ л дуулчих. Яриад өгчихөөч дээ!

- За за, ярихаас биш дээ, бүр дуулсан ч яахав, дэлгэрэнгүй ярья гэвэл барагдахгүй, товчлохоос өөр аргагүй. Одоо орой болж байна, маргааш зөвлөгөөн хийж, том ажил ярих хэрэгтэй, замд гарахад ч бэлдэх хэрэгтэй боллоо шүү дээ. Ерөөс тэр тухай санахад гайхалтай, ярихад гунигтай – гэж тэр хэлээд хэсэг бодолхийлснээ. - Газар сайгүй Зүүрмэглэгч ой эцэс хязгааргүй найган шуугиж байх тэр их эрт цагт онтууд, онтжингууд, онтуухайнууд, онтуужингууд хамтдаа амьдарч байсан юм.

Намайг идэр залуу явсан тэр балар эрт цагт миний Фимбретили – хөнгөн хөлт Мэндүүжингээс сайхан нь энэ хорвоод үгүй байлаа. Тэр минь одоо хаана яваа бол доо..., өө нээрэн тийм л дээ, өршөөгөөрэй би хадуурчихлаа. За тэгээд онтууд онтжингуудтайгаа хамтдаа ойгоор хэсч, хамтдаа орон байраа бэлддэг байлаа. Гэвч тэдний зүрх сэтгэл нийлдэггүй байлаа. Онтууд ертөнцийн бат бэх, хүчирхэгийг сонирхож, онтжингууд уян зөөлөн, уран нарийныг сонирхдог байлаа. Онтуудад өндөр нарс, гоолиг хус, өтгөн навчис, бүдүүн урт мөчир, эгц өндөр уул таалагддаг, тэд зөвхөн булгийн ус уудаг байсан юм. Эльфүүд

тэдний багш болсон, тэд мододтой эльфүүдийн хэлээр ярьдаг байсан. Харин онтжингууд болохоор жижиг мод, бутыг асрах дуртай, тэд уулын бэлийн ойн нугад туссан нарны туяанд баясдаг, хавар цагт усан үзэм, алим гээд л янз бүрийн жимсний бут цэцэглэхэд баярладаг, зун цагт аглаг ойн аливаа ургамал бүхэн ханатлаа цэцэглэж, хагдартлаа цэнгэхийг хараад жаргадаг, намар цагт үндэстэй бүхэн үрээ өгөхөд санаа амардаг байсан юм. Онтжингууд тэдэнтэйгээ ярих хэрэг байгаагүй, цаадуул нь зөвхөн сонсдог, хэлсэн бүгдийг нь биелүүлдэг байсан юм. Онтжингууд тэдэнд ургах жамаараа ургаж, үр жимсээ үржих жамаар нь үржүүлэхийг тушаадаг байсан. Харин онтчуудад эмх цэгц, энх амгалан, элбэг дэлбэг хэрэгтэй байлаа.

Онтжингууд баян тансаг цэцэрлэгүүд ургуулдаг байсан. Онтууд урьдын адилаар газар сайгүй хэсүүчилсэн хэвээрээ, хааяа нэг тэдний цэцэрлэгүүдээр ордог байлаа. Дараа нь умард нутгийг харанхуй бүрхэж, онтжингууд Их мөрний цаана гарч, тэндээ шинэ цэцэрлэг ургуулан, агар газар хагалж, тариа тарьдаг болсноос хойш бид цөөхөн уулздаг болсон. Харанхуйг бид ялсан, тэр цагт бидний бүсгүйчүүдийн газар улам ч цэцэглэн, энэ дэлхийд тэднээс баян ургац хураадаг газар нэгээхэн ч үгүй байсан сан.

Янз бүрийн омгийн хүмүүс тэднээс дэлхийг тэтгэн, дэлхийн шимийг хүртэх урлагийг сурч, манай бүсгүйчүүд тэдний шүтээн болж байх үест эрчүүд бид оргүй алга болсон мэт сураг чимээгүй болж, бараг мартагдсан үлгэр домгийн харанхуй ойн нууц болсон юм даа. Гэтэл одоо бид байж байдаг, харин бидний бүсгүйчүүдийн гайхамшигт цэцэрлэгүүдээс юу ч үлдсэнгүй. Хүмүүс тэдний байсан газрыг Хүрэн тал гэж нэрлэдэг болсон.

Өөр нэг юм санаж байна, Тэнгисийн цаанаас ирсэн баатар вангууд Сауроныг олзолсноос хойш хичнээн он жил улирсан ч би Фимбретилийгээ хармаар байх юм. Тэртээ өнгөрсөн тэр цагт би түүнийгээ сүүлчийн удаа харахад тэр минь орь залуугийнх шигээ биш болсон байсан ч гэлээ одоо би түүнийгээ орь залуугийнх нь төрхөөр санаж байна. Өтлөлгүй ч яахав дээ, тэд нар минь борви бохисхийлгүй хөдөлмөрлөж, нуруу нь бөгтийж, нүүр нь борлож, үс нь наранд гандаж, хацар нь алим шиг ягаарсан шүү дээ. Гэлээ ч гэсэн тэдний минь нүд өөрийнхөөрөө, ногооноороо үлдсэн дээ. Бид Андуиныг гаталж, тэндхийн хязгаарт очиход дайны хөлд гишгэчүүлж, эзэнгүй цөл болсон газрыг л харсан. Онтжингууд минь тэнд байгаагүй. Бид тэднийгээ нэрээр нь дуудаж, их удаан хайсан, тааралдсан болгоноос асууж сурагласан. Зарим нь тэднийг үзэж хараагүй гэгцгээж, зарим нь баруун зүг рүү, зарим нь зүүн зүг рүү, зарим нь өмнө зүг рүү явж байхыг нь харсан гэж байлаа. Бид тэр бүх зүг рүү нь явсан боловч олоогүй юм даа. Бидэнд маш харамсалтай, гашуудалтай байсан. Гэвч ой маань биднийг дуудсан учраас бид өтгөн ойдоо эргээд ирсэн. Олон жил дараалан бид ойгоосоо гарч, тэднийхээ мартагдашгүй энхрий нэрийг хичнээн дуудсан ч хариу дуулдаагүй. Дараа нь цөөхөн ч гардаг болсон, хол явахаа ч больсон.

Одоо тэд маань хэзээ ч байгаагүй юм шиг болсон, зөвхөн бид хэдийн ой дуртгалд л үлдсэн, бид урт буурал сахалтай боллоо. Эльфүүд бидний тэднийгээ эрж байгаа тухай олон дуу зохиосон, дараа нь хүмүүс тэр дууг нь өөрсдийнхөөрөө дуулдаг болсон. Бид тэднийхээ тухай дуу зохиогоогүй, зөвхөн нэрийг нь л санаж, нэрээр нь л дууддаг байлаа. Магадгүй, бид тэдэнтэйгээ учирч, хамтдаа амьдрах хязгаар нутаг олдож ч болох юм. Гэхдээ бид дахиад уулзлаа гэхэд байсан бүхнээ алдаад, одоо байгаагаа ч алдаад уулзана. Тэгэх л гэж байх шиг

байна. Тэр цагт цэцэрлэгүүдийг шатааж байсан тэр Саурон одоо бүх ойг үндсээр нь үгүй хийх гэж байх шиг байна.

Тийм дээ, энэ бүхний тухай эльфүүд аль дивангарт нэг ийм дуу зохиосон юм. Эльфүүдийн дуу л даа, энэ дууг Их мөрний хөвөөгөөр газар сайгүй л дуулж байлаа. Бид ингэж дуулж чадахгүй, хэтэрхий урт, удаан аятай дуулах байсан. Танай хэлээр бол нэг иймэрхүү л юм даа:

ОНТ:

Цагаахан хус ногоохон навчсаар гоёж,

Амин шүүсээр ханалаа.

Цасны уруй өндрөөс тонгочин бууж,

Алтан нарнаа гялалзлаа.

Цагийн салхи шинэхэн амьсгалаар сэнгэнэж,

Алсын ууланд цуурайллаа.

Хурдхан ирээч, хурдхан ирээч наддаа,

Хаврын хөгжөөнт хязгаартаа!

ОНТЖИН:

Цэлмэг тал хөндий хавраар үерлэж,

Ногоон мандлаар давалгааллаа.

Цэцэг ногоо хаврын шүүдрээр гялалзаж,

Мөнгөн цацал хаяллаа.

Цацрах нар, цацлах бороо ээлжилж

Газрын цангааг тайллаа

Цэцэглэж буй хөндийгөө орхиод би

Чам руу яаж очих юм бэ?

ОНТ:

Намуухан зуны өдөр дэлхийг нөмрөн ээж,

Нарны гэрэл ойг алтадлаа.

Навчсан нөмрөгт ойн зүүд

Намайг тойрон эргэлдлээ.

Нам гүм, нов ногоон ойн өргөөнд

Намрын салхины түүчээ үнэртлээ.

Наддаа ирээч! Над руу эргээч!

Ертөнцийн сайхан хязгаартаа!

ОНТЖИН:

Нарны халуун, намрын амьсгалд

Жимсний хацар хүрэнтлээ.

Намирсан тарианы сувдан үрийг юу юугүй

Над руу зөөж авчрах нь ээ,

Намрын салхи үлээвэл үлээг

Надад чам руу очих зав алга аа!

ОНТ:

Харанхуй өвөл дорноос ирж,

Хар сүүдэр нь нөмрөх нь ээ.

Хав харанхуй тэнгэрийг бүрхэж,

Хагдарсан ойг залгих нь ээ.

Хар шуурга бүхнийг хөнөөж,

Хамаг итгэл бөхөх нь ээ,

Хэрэв чи ирдэггүй юм бол би

Хэрэн хэссээр чамайг олно оо!

ОНТЖИН:

Үзэгдээгүй тэр өвөл ирвэл

Үндэс бүхнийг тасална,

Үйлс бүгдийг минь хөнөөж,

Үхээрийн инээдээр даажигнана.

Тэр цагт чи бидэн хоёр дахиад,

Бие биенээ олно оо.

Тэгээд хоёул хамтдаа хар бороон дундуур

Тэнгэрийн хаяа руу одно оо!

ХОЁУЛАА:

Бидэн хоёр хамтдаа сэтгэшгүй замаар

Хүршгүй хязгаарт очно оо!

Бидэн хоёрт шинэ нутаг нээгдэж,

Амьдрал дахиад цэцэглэнэ ээ.

Модон аягатайгаа хөнтрөөд хэсэг чимээгүй болов.

- Тийм ээ, нэг ийм л дуу даа, - Эльфүүдийн дуу шүү дээ, тэд чинь дуулах гэж төрсөн амьтад. Амаа ангайгаад л, ая аялаад л арав таван үг хэлээд л болоо. Гэхдээ энэ дууг тун ч муугүй зохиосон шүү, ярих юм байхгүй. Харин онт биднийгээ жаахан гомдоосон. Дэндүү богинохон. За тэр ч яахав, жаахан зогсч унтъя даа. Ингэхэд та хоёр маань хаана зогсох гэж байна даа?

- Бид уул нь зогсоогоороо унтдаггүй л дээ, хэвтэж унтдаг ухаантай, болох юм бол энэ вандан дээр л унтаад өгье – гэж Мерри хэлэв.

- Хэвтэж унтана гэдэг чинь юу гэсэн үг вэ? – гэж Модон гайхсанаа: Өө нээрэн тийм л дээ! Гм, кгм, би будилж байна. Эртний дурсамж сэргээд, онтуухайнуудтайгаа ярьж байгаа юм шиг санагдаж л дээ, ээ зайлуул даа чи! За тэгвэл орон дээр хэвтээд унтацгаа. Би горхины доор зогсоно. Сайхан нойрсоорой!

Хоббитууд вандан дээр авирч гараад, шинэхэн, зөөлхөн, дулаахан өвсөнд толгойгоо шургуулан хэвтэв. Дэнлүүнүүд нэг нэгээрээ цувран унтарч, олон өнгийн модод бүдгэрсэн боловч Модон гараа ар шилэн дээрээ аваад нуман хаалганы доор хөдөлгөөнгүй зогсч байгаа нь харагдаж л байв. Оддын туяа түүний хөлийг даган чимээгүйхэн гулсч байгаа урсгал дээр тусан гялалзаж, мянга мянган мөнгөлөг дуслууд жин жин авиа гаргаж байв. Мерри Пин хоёр энэхүү дуслын жингэнээнд бүүвэйлүүлэн нам унтлаа.

Мань хоёрыг сэрэхэд саглагар ногоон өргөөг өглөөн нар гийгүүлж, өндөр тэнгэрт дорнын

салхи үүдэг түүдэг үүлсийг үлдэн хөөж авай. Модон хаа нэг тийшээ алга болжээ. Мань хоёр хоббит нуман хаалганы цаадах усан санд сэлэхээр явж байх зуур түүний хүнгэнэн дуулах сонсдож, төдөлгүй тэр моддын дундах өргөн жим дээр гарч ирэв.

- Кгм, кха! За, өглөөний мэнд, Мерри, Пин хоёр гуай, - гэж тэрбээр мань хоёр хоббитыг харангуугаа мэндлээд: - Та хоёр ч унтахдаа ёстой баатар юм аа! Гэтэл би мянгаад алхчихаад ирлээ. Одоо усаа уучихаад Онтхур явна аа!

Тэр өчигдрийнхөөс өөр нэг торхноос хул дүүрэн дүүрэн ус хийж өгөв. Тэр усны амт өчигдрийнхөөс тэс өөр, өтгөн бөгөөд өег, умдаа биш хоол юм шиг санагдав. Хоббитууд өндөр вандангийн ирмэг дээр суугаад умдаагаа балгангаа эльфийн талх-бингээсээ хазлав. (Тэр хоёр огт өлсөөгүй байсан ч нэгэнт өглөөний хоол юм чинь ямар нэг юм зажилмаар байлаа). Харин Модон тэр хоёрыг хүлээнгээ тэнгэр өөд хараа бэлчээн онт ч юм уу, эльф ч юм уу, өөр ч юм уу мань хоёрын үл мэдэх хэлээр дуу аялж зогсов.

- Таны тэр Онтхур чинь хаана байдаг юм бэ? – Пин зориглон асуув.

- Кгм, юу гэнэ ээ? Онтхур хаана байдаг юм бэ гэв үү? – хэмээн Модон эргэж хараад: - Энэ бол газар орон биш, онтуудын хуралдай, одоо ийм хуралдай тун ч цөөхөн хийдэг болсон. Гэвч өнөөдөр олон онт хуралдайд ирнэ гэж надад амласан. Бид урьдын цуглардаг газраа хурнав Хүмүүсийн хэлээр бол Нууц хөндий гэдэг юм. Бид тэнд бага үдэд очсон байх ёстой.

Удалгүй тэд замдаа гарлаа. Модон хоёр хоббитыг мөрөн дээрээ суулгаж, өргөөнөөс гармагц баруун тийш эргээд, түргэн урсгалт горхин дээгүүр алхан гаталж өмнө зүг рүү чиглэв. Дараа нь хоббитуудын амьдралдаа үзээгүй аварга бүдүүн, асар өндөр моддын дундуур орлоо. Эхэндээ хоббитууд анх Фангорны ой руу орсонтой адил амьсгалахад бэрх болсноо удалгүй зүгээр болов. Модон нэг ч үг хэлсэнгүй, зөвхөн хамар дороо аяархан бувтнаж явсан бөгөөд хоббитуудад “бум-бум, рум-бум, бух-трах, бум-бум, трах-бах, бум-бум, та-ра-рах-бум” гэсэн авиа л сонсдож байв. Заримдаа түүнд хариу өгч байгаа мэт авиа газраас ч юм шиг, толгой дээрээс ч юм шиг, моднуудаас ч юм шиг сонсогдож байсан боловч Модон ийш тийш харалгүй чигээрээ алхсаар байлаа.

Пин Модонгийн дунд зэргийн “онт алхаа”-г тоолж явсан боловч гурван мянга хүргээд тоо алдав. Тэгтэл Модон арай удаан алхаж байснаа гэнэт зогсоод хоббитуудыг өвсөн дээр буулгаж, алгаа аман дээрээ бүрээ мэт бариад ой дүүрэн хүнгэнүүлэн цуурайтуулав.

Уриалан дуудах мэт “Гу-у-гу-у-гу-умм!” цуурай эргэн тойронд алслан хүнгэнэж, модод тэр цуурайг давтаж байгаа нь илэрхий байлаа. Дараа нь тал талаас “Гуу-гу-у-гу-у-гу-у-гумм!” хэмээн хариу цуурайтлаа.

Модон дахиад хоббитуудыг мөрөн дэрээ суулгаад цааш алхахдаа байн байн уриагаа давтаж байлаа. Хариу цуурайнууд улам л ойртсоор. Тийнхүү алхсаар мөнх ногоон моддын нэвтэршгүй хананд тулж очив. Тэнд хоббитуудын урьд өмнө үзээгүй олон төрлийн модод байсан бөгөөд цөм үндэснээсээ дээш өтгөн навчтай, тосон боргоцойтой байв.

Модон зүүн тийш эргэж хэдхэн алхахад амьд хана гэнэт нээгдэж, нарийхан гарцаар доошлон,

дээгүүрээ мөнх ногоон дээвэр бүхий уудам дугариг хөндий рүү оров. Хөндийд нэг ч мод байсангүй, зөвхөн тэг дунд нь цас мэт цагаан гоёмсог гурван хус тэнгэр баганадан байв. Баруун зүүн хоёр талаас өөр хоёр зөрөг орж ирсэн байна.

Онтуудын зарим нь аль хэдийн ирчихсэн, зарим нь тэр хоёр зөргөөр цувж, нөгөө хэсэг нь Модонгийн араас бууж байлаа. Пин, Мерри хоёр эргэн тойрноо хараад мэл гайхаж хоцров. Онтууд хоббитууд шиг хоорондоо адилхан гэж бодож байсан нь үгүй ажээ: Модод хичнээн олон төрөл байдаг шиг тэд төчнөөн олон байв.

Олон зуун настай хүчирхэг хөгшин мод мэт урт сахалтай, хатангир онтууд ч байна (гэхдээ л Модонгоос хавигүй залуу нь илт), чилгэр чийрэг, өгөөмөр дүртэй хижээл аваргууд ч байна, харин идэр залуу онт нэг ч байсангүй. Гурван хусны дэргэд хориод онт цугларч, гурван талаас дахиад хорь орчим онт ирж яваа харагдана. Эхлээд хоббитууд тэдний өөр хоорондоо ийм их адилгүйг хараад нүд нь эрээлжилж байв. Өндөр нам, өнгө зүс, өргөн бүдүүнээрээ өөр өөр, гар хөл нь янз бүрийн урттай, хурууны тоо нь ч янз бүр (гурваас есөн хуруутай байв). Царстай төстэй зарим нь Модонгийн төрөл садан байж магадгүй боловч ихэнх нь түүнтэй огт төсөөгүй байлаа. Зарим нь улиангартай төстэй, хүрэн арьстай, асар том сарвуутай, богино бүдүүн хөлтэй. Зарим нь нарстай төстэй, өндөр нуруу, саарал арьстай, олон хуруутай, урт хөлтэй. Гацуур, хус, далдуу гээд төрөл төрлийн модтэй төстэй онтууд ч байна.

Гэвч бүх онтууд Модонгийн дэргэд бөөгнөрч, ёсорхоогоор мэхийн, чихэнд чимэгтэй дуугаар хүндэтгэн мэндлээд, харийн хачин хоёр залууг яаралгүй, анхааралтай ширтэхэд л тэд хоорондоо хичнээн адилхан болохыг мань хоёр мэдэв. Тэдний нүд бүгд ижилхэн, Модонгийнх шиг ёроолгүй гүн биш нь мэдээж боловч амгалан дөлгөөн, бодлогошронгуй, анхааралтай, ногоон оч цацруулсан нүднүүд байв.

Сүүлчийн онтууд амжиж ирлээ. Тэд Модонг өргөн хүрээгээр тойрон зогсоод, туйлын сонирхолтой, нууцлаг яриа өрнүүлэв. Онт бүр өөрийн ээлж болоход үг хэлж байлаа. Пин тэдний үгийг ялгаж салгаж чадахгүй, яриаг нь ойлгохгүй байлаа. Онтууд ямар ч гэсэн онт хэлээрээ ярьж байсан нь эхлээд их сонирхолтой санагдаж байснаа сүүлдээ уйдаж эхлэв. Тэр сонсч сонсч (тэд яриад л, дуулаад л байлаа) эцэст нь онт хэл дэндүү удаан аялгуутай юм байна даа гэж бодов. Тэд бие биетэйгээ мэндэлсэн болов уу, Модон тэднийг нэрээр нь дуудахад тэд нэрээ хэзээ хэлж дуусах юм бол гэдэг нь сонин байна. “Онт хэлээр за, үгүй хоёрыг юу гэдэг юм бол? Мэдэх юмсан” – гэж тэр бодоод эвшээв.

Модон тэр дор нь мэдэрлээ:

- Кгм, кха-кха, чи юу болов оо Пин, найз минь - гэж тэр хэлэхэд онтуудын дуу шуутай хүнгэнээн нам гүм болов.

- Та нар ийм хачин яаруу гэдгийг би мартаж орхижээ. Мэдэхгүй хэлээр бусдын яриаг сонсоно гэдэг ч уйтгартай л даа. Явж зугаалцгаа. Та хоёрын нэрийг онтуудад зарласан, бүгд та хоёрыг ажигласан, та хоёр орк биш гэдгийг бүгдээрээ мэдсэн, эртний нэрсийн жагсаалтад нэг нэр нэмэхийг ч зөвшөөрсөн. Одоохондоо бид ингэж шийдээд байна, хурдан шийдсэн гэж би хэлмээр байна, арай л хурдан шийдсэн байж магадгүй. Мерри та хоёр одоохондоо хөндийгөөр зугаал, та хоёрт юу нь муу байх билээ. Юм уумаар байвал тэр хойт бэлд их сайхан амттай

булаг байгаа. Харин бид жинхэнэ онтхур хийхийн тулд нэлээд сайн ярилцах хэрэгтэй байна. Дараа нь би та хоёрт бид юу ярилцсанаа мэдээлнэ.

Тэрбээр Пин, Мерри хоёрыг газарт буулгахад мань хоёр тохиролцсон юм шиг зэрэг гүнээ мэхийн талархал илэрхийлэв. Энэ нь онтуудад маш таалагдсан бололтой хоорондоо ямар нэг юм ярилцахад харцнаас нь ногоон очис цацарч байв. Гэвч үнэндээ тэд хоббитуудын тухай ярихтай манатай байжээ. Нөгөө хоёр нь баруун зөргөөр дээш гүйж одлоо. Нууц хөндийн баруун талын ногоон хаалтын цаана юу байгаа нь тэдэнд нэн сонин байв. Тэнд ойрхон уулс байх бөгөөд гацуурт ойгоор бүрхэгдсэн өндөр уулын цаана цасан цагаан оргил гялалзаж үзэгдэв. Зүүн талд, өмнө зүгт бас л ой үргэлжилсээр цайвартан ногоорох алсад бараа тасарчээ. “Магад Ристанийн тал биз” – гэж Мерри таамаглав.

- Изенгард хаахна байдаг юм бол? - гэж Пин асуув.

- Би яаж мэдэхэв дээ, бид хоёр одоо хаана байгааг ч мэдэхгүй байна, хэрэв энэ оргил Метхедрасын оргил мөн бол түүний бэл дэх гүн хавцалд Изенгард байх ёстой. Энэ урт нурууны зүүн талд л байгаа болов уу. Чи тэр манан шиг утаа суунаглаж байгааг харж байна уу?

- Изенгард ямаршуу цайз юм бол? Онтуудад арай ч автагдахгүй биз дээ – гэж Пин хэлэв.

- Би ч бас тэгж бодож байна, Изенгард бол хад асгаар хүрээлэгдсэн хүрээ, дотор нь чулуун шал, дунд нь Ортханк гэдэг гантиг чулуун цайз байгаа. Тэр цайзын оройд Саруман суудаг. Олон давхар гантиг цайз шүү дээ. Эргэн тойронд нь ямар ч хэрэмнээс зузаан хадан хясаа байгаа, хэдэн ч хаалгатай юм бүү мэд. Онтуудад тэнд хийх юм байхгүй байх аа. Онтуудыг би ойлгохгүй юм. Тийм ч номхон хүлцэнгүй биш, тийм ч инээдтэй биш. Гаднаас нь харахад гайхмаар тэвчээртэй, номхон дөлгөөн, гунигтай, гомдож цөхөрсөн, амьдралд нухлагдсан юм шиг харгдах юм. Гэвч тэднийг гомдоосон бол толгойгоо сугандаа шургуулаад, өсгийгөө сайтар тослоод зугтаасан нь дээр юм шиг.

- Тийм шүү, хөгшин үнээ хэвтэртээ хэвтээд, хивж байснаа нүд ирмэх зуурт хөгшин үнээ биш, идэр бух болоод ухасхийн дүүлэх юм шиг. Хөгшин Модон тэднийг хөдөлгөсөн нь сайн хэрэг. Тэгэх л гэж эднийг цуглуулсан байж таарна. Гэхдээ энэ бол хэцүү ажил л даа. Өчигдөр тэр ганцаараа яаж хилэгнэж байсныг санаж байна уу? – гэж Мерри яриу.

Хоббитууд хөндийд эргэж ирлээ. Онтхур ид дундаа орж, дэндүү удаан яриа хөөрөө нь нэг ширүүсэн чангарч, нэг намсан зөөлөрч байлаа. Нар өндөрт мандаж, хөндийн дундах гурван хус мөнгөн цацлаг хаялан, умард уул шаргал гэрлээр гийлээ. Үзэгдэхгүй байсан булаг гялалзан туузарч харагдав. Хоббитууд дугариг хөндийн захаар тийш явахад шинэхэн зөөлөн ногоон дээгүүр яаралгүй тайван алхах тун ч аятайхан байлаа. Нарны туяанд цацран оргилох булгийн шүд хага ташим уснаас уугаад мань хоёр элэгдэж мөлийсөн чулуун дээр сууж, үүлсийн сүүдэр, нарны цацраг ногоон дээгүүр хэрхэн тоглож байгааг баахан харав.

Онтхур чимээгүй боллоо. Энэ газар нэг л ойлгомжгүй, нэг л их холын, огт өөр ертөнц шиг санагдаад байлаа. Андуудынхаа, тэр тусмаа Фродо, Сэм, Тэнэмэлийн царайг нь харж, дууг нь сонсохсон гэхээс нулимс мэлтэрч байв.

Гэнэт Модон ирж яваа харагдав. Тэр ганцаараа биш, нэг найзтайгаа ирж явна.

- Кгум, кгу-гум, за би хүрээд ирлээ, та хоёр минь уйдаж, хамаг тэвчээр чинь барагдаж байгаа биз дээ, кгмм, тийм байлгүй яахав. Үгүй шүү, тэвчээрээ сайн нөөцлөх хэрэгтэй болоод байна. Эхний удаад бид бүх асуудлыг хэлэлцэж, энэ ч яахав, одоо ярьж хэлэлцсэнээ Изенгардаас хол байгаа манайхан, бас өглөө би уулзалдаагүй нөхөддөө мэдээлэх хэрэгтэй байна, дараа нь юу хийхээ бүгдээрээ хэлэлцэж шийднэ. Онтууд юу хийх ёстойгоо нэгд нэггүй ярьж хэлэлцсэн л бол шийдвэр гаргах нь хурдан. Гэвч зөв шийдвэр гаргахад дахиад нэг өдөр хэрэгтэй байна. Тиймээс би та хоёр дээр найзыгаа дагуулж ирлээ. Энэ маань эндээс холгүй амьдардаг, нэрийг нь эльфээр Брегалад гэдэг юм. Энэ маань би бэлэн, онтхур дээр надад хийх юм алга гэж байна. Гм, гм, ийм яаруу онт ертөнц дээр байдаггүй л юм даа. Та гурав учраа ололцоно биз. Баяртай! - гэж хэлчихээд Модон яваад өгөв.

Брегалад хөдөлгөөнгүй зогсоод хоббитуудыг нүд салгалгүй харж, цаад хоёр нь түүний юу хэлэхийг хүлээн суулаа. Өндөр чилгэр, уян хатан байрын тэр онт өөрсдийнхөн дундаа залууд тооцогддог бололтой. Гар, хөл нь гялазсан гилгэр хальстай, хүрэн улаан уруултай, саглагар ногоон саарал үстэй ажээ.

Брегалад ярьж эхлэхэд дуу хоолой нь Модонгийнх шиг чанга боловч арай нарийн, тодхон аялгуутай байв.

- Кха-ха, эге-гей, хүүхдүүд ээ, явж зугаалцгаая! - гэж тэр уриад - Намайг Брегалад гэдэг, танайхаар бол Хурдан гэсэнтэй адилхан. Манай нэг өвгөн надад маш чухал асуулт тавих гэж байтал би “Мэдээж тийм” гэж хэлснээс хойш намайг ингэж нэрлэдэг болсон юм. Үнэндээ бол нэр биш, зүгээр л хоч л доо. Би бас их хурдан уудаг, хүндэт онтууд дөнгөж сахлаа норгож байхад би аль хэдийн уучихаад уруулаа арчиж байдаг юм. За явъя, - гээд тэр гоё урт гараа сунгав. Тэр гурав өдөржин ойгоор тэнэж, хоолой нийлүүлэн дуулж, инээж хөгжилдөв. Хурдан үүлэн цаанаас нар гарч ирэхэд инээнэ, горхи булаг харахдаа ч инээнэ, хөл, толгойгоо усаар норгоод л инээгээд байна. Навчсын сэржигнээнийг сонссон ч инээнэ. Жим хараад гараа алдлан зогсоод дуулна.

Орой болоход тэр мань хоёр хоббитыг гэртээ дагуулж ирэв. Үнэндээ гэр гэх юм байхгүй, зүгээр л тавлаг ногоон хонхорт нэг том хөвдөөр хучигдсан чулуу л байв. Тэр хонхор жимсээр дүүрэн, дээрээс нь жижигхэн горхи шулганан урсана.

Онтуудын цуглаан өтгөн баргил дуугаар хүнгэнэлдэн, байн байн хэн нэгнийх нь дуу хоолой бусдаасаа чангарахад нийтийн хүнгэнээн намсч байлаа. Тэдний яриаг Хурдангийн намуухан яриа тасалж, хоббитуудад түүний танил дуу тун ойлгомжтой байв. Тэрбээр эртний сайхан хязгаарыг нь дайснууд хоосруулсан тухай ярьж байв. “Түүнд орхуудтай онцгой тооцоо байгаа юм байна, удаан бодолгүй ярьж байна” гэж хоббитууд бодлоо.

- Миний гэрийг улаагана жимс бүчдэг байсан, тэр жимснүүд өнө эртнээс ойн нам гүмд надтай хамт өссөн юм. Заримыг нь онтжингуудад зориулж суулгасан юм. Онтжингууд тэднийг хараад инээмсэглэн толгой сэгсэрч “Манай газрын жимс том, цэцэг нь гэрэлтэй” гэдэг байсан. Харин надад бол манай модод, цэцэг, жимснээс сайхан нь үгүй байсан. Тэд минь ургаад л, өсөөд л, өтгөн навч мөчрийнхөө сүүдрийг унагаан намар болохоор

гайхамшигт жимсээ дааж ядан сугсардаг байсан юм. Шувууд сүрэг сүргээрээ нисэн ирж, тансаг жимсний найр хийдэг байлаа. Би шувуунуудад хайртай, тэдэнд жимс хангалттай хүрэлцээд илүү гардаг байсан. Гэтэл шувууд гэнэт хачин бүдүүлэг, хорон санаатай, ховдог шунахай болж, моддыг тарчлаан, үр жимсийг нь тоншиж хаядаг болсон. Орхууд том сүх барьж ирээд, миний жимсний моддыг цавчиж хаясан. Дараа нь би ирээд тэднийг мартагдашгүй сайхан нэрээр нь дуудахад тэд маань нэрээ ч сонсохгүй, хариу ч хэлэхгүй болсон байлаа.

О Орофарнэ, Лассемисте, Карнимириэ!

Миний гоёхон, бардамхан модод минь!

Миний хараад ханашигүй улааганууд минь,

яаж та нарыгаа харах билээ?

Хаврын цэцэг та нарыг минь

мөнгөн нөмрөгөөр хучдаг сан.

Зуны өглөөг та нар минь

Тодхон гоёлоороо гялбуулдаг сан.

Уяхан эелдэг дууг чинь сонсч,

Улаахан өнгөнд чинь дурладаг сан.

Үүр оромж чинь тэгтэл

Саарал тоосонд дарагдаж,

Үүрд та нарынхаа дууг сонсохгүй,

орь ганцаараа үлдлээ би.

О Орофарнэ, Лассемисте, Карнимириэ!

Хамгаас хайртай модод, зүйрлэшгүй сайхан цэцэг жимсээ харамсан дурсах Хурдангийн гунигт дууг сонсон байсаар хоёр хоббит нам унтжээ.

Маргааш өглөө нь тэр гурав яаралгүй босч, Хурдангийн оромжийн ойролцоо зугаалж өнжив. Салхи сэрүүсч, нар саарал үүлсийн завсраар хааяа нэгхэн шагайж байв. Онтуудын дуу нэг чангаран хүнгэнэж, нэг намсан аядаж, нэг уйтгарлан уянгалж, нэг нижигнэн цуурайлж байв. Хоёр дахь шөнө болж, хуралдай үргэлжилсээр. Хурдлан нүүж буй үүлсийн завсраар одод жирвэлзэв.

Гурав дахь өглөө салхитай, бүрхэг байв. Онтхур нэгэнтээ чангарснаа дахин намжив. Тэнгэр цэлмэж, салхи намдан, агаар ямар нэг чухал юм хүлээх мэт хүндэрч байв. Хуралдай болж байгаа газраас тэр гурвын суугаа хонхорт бүдэгхэн дүнгэнээн сонсдож байсан ч Хурдан хоёр чихээ дэлдийтэл чагнаж байв.

Нар баруунаа ташиж, үүлэн завсраар урт шаргал туяа гийж байлаа. Нэг л хачин нам гүмхэн, чимээгүй боллоо. Ингээд онтуудын хуралдай дуусав. Ямар шийдвэр гаргасан бол? Хурдан Нууц хөндийн зүг хараачлан чимээгүй зогсов.

Гэнэт ойгоор дүүрэн эвсэг чанга дуу нүргэлэв:

“Тррам-тарарам-тарам!” Модод шуугин шивнэлдэж, шуурганд налах мэт бөхийв. Дахиад нам гүм болсноо бөмбөрийн цохилт мэт нэгэн хэвийн нүргээн хадав:

- Аянга мэт бөмбөр дэлдэн явцгаая: трамбам-барамбарам-бам-бом!

- Аймшигт шүүх зарлан явцгаая: трумбум-бурумбурум-бум-бом!

Онтууд ойртож ирэхэд тэдний аяны дуу улам чангаран нижигнэлээ. Хурдан хоёр хоббитыг яаран босгож, хонхроос гарлаа.

Тэдний өөдөөс тавь гаруй онт хоёр эгнээ жагсан нэгэн хэмээр том том алхлан ирлээ. Тэдний манлайд Модон явах бөгөөд бүгд хоёр гараараа гуя руугаа дэлдэн бөмбөрдөж байв. Тэдний нүд ногоон галаар дүрэлзэж үзэгдэв.

- Кхум-кхам! Бид хүрээд ирлээ дээ. Биднийг удаан хүлээгээгүй биз дээ! – гэж Модон тэр гурвыг харангуугаа өгүүлээд: - Жагсаалд орцгоо! Бид аян дайнд явж байна. Изенгард руу урагшаа!

- Изенгард руу урагшаа! – хэмээн онтууд нэгэн дуугаар нижигнүүлэв.

Изенгард руу урагшаа!

Ханан хадаар хүрээлэгдсэн л биз,

Нэвтэршигүй цайз дотроос

Хохимой толгой ярзайна л биз,

Нэгэнт бид очих юм чинь,

Изенгард тэсэхгүй!

Харлаж шатсан модод,

Хилэгнэж байна -

Хилэнт заяаны хүчирхэг хөлөөр

Хэрэм цайзыг нь газартай тэгшилье!

Аянга мэт бөмбөр дэлдэн явцгаая,

Аянгаар ниргээж, заяагаа аварцгаая!

Онтууд ийнхүү нижсигнүүлэн дуулж өмнийг чиглэв.

Нүд нь гялалзан гийсэн Хурдан тэдний жагсаалд нэгдэж Модонгийн ард байраа эзэллээ. Модон хоббитуудыг мөрөн дээрээ суулгаад алхаагаа түргэсгэхэд мань хоёр хоббит араас нь дагаж яваа онтуудыг харж хийморь сэргэн тэдний аймаар ч юм шиг, бахадмаар ч юм шиг гайхамшигт дууг нь сонсон гайхаж явлаа. Тэр хоёр эцсийн эцэст ямар нэг юм болно гэж найдаж байсан боловч их мөрний үер далангаа зад татах мэт ийм сүртэй юм болно гэж бодоо ч үгүй билээ. Онтууд дуулахаа больж, зөвхөн нир нирхийсэн сүрлэг алхаанаас нь өөр чимээ дуулахгүй болоход гэнэт их зориг орсондоо амьсгаа нь давхацсан Пин:

- Онтууд мөн ч хурдан шийдвэр гаргалаа шүү, тийм үү? – гэж асуув.

- Хурдан гэж хэлэв үү чи? – хэмээн Модон асуугаад: - Хм! Тийм дээ, нээрэн хурдан шийдлээ. Миний бодсоноос л лав хурдан шийдлээ. Бид сүүлчийн удаа хэзээ ингэж их уурласнаа санахгүй байна. Олон зууны өмнө байх аа. Бид уурлах дургүй, тун ч ховорхон уурладаг, бид болоод бидний ойд мөхөл ирснийг мэдрэхээрээ л уурладаг юм. Саурон дайн дэгдээж, тэнгисийн чанадаас баатар вангууд ирснээс хойш бид анх удаа ийн хилэгнэж байна. Энэ муу орхууд – хараал идсэн хар мод цавчигчид хэрээс хэтэрч байна, түлэх модоо цавчдаг бол яахав гэхсэн, түлээнд хичнээн мод ороо аж, гэтэл муусайн үхээрүүд сүйтгэж сөнөөхийн тулд хайр найргүй цавчиж байна. Ийм үед хөршөөсөө тусламж горьдох ёстой байтал тэр муу Саруман дайсантай нийлчихдэг байна шүү. Үгүй ээ, хэрэв чи шидтэн юм бол онцгой ачаа үүрэх ёстой. Бусад шидтэнгүүд түүний дэргэд юу ч биш юм гэнэ ээ. Эльфийн ч, онтын ч, хүний хэлэнд тэрэнд таарах хараал олдохгүй байна. Саруман сөнөтүгэй, тэгээд л гүйцээ!

- Та нар үнэхээр Изенгардын цайзыг хэмх нураах гэж байгаа юм уу? - гэж Мерри болгоомжтой асуув.

- Ха, хм-м, чамд юу гэж хэлмээр юм бэ дээ, ер нь яагаад болохгүй байх билээ! Бид ямар их хүчтэйг та хоёр яаж мэдэх вэ дээ. Тролл нарын тухай дуулсан уу? Тэд маш их хүчирхэг. Гэхдээ тэд энэ ертөнцөд өөрсдөө ирээгүй юм, мөнхийн дайсан тэднийг их харанхуйн дор эльфүүдийг орхуудаар даруулах гэсэнтэйгээ адил онтуудыг даруулах гэж авчирсан юм. Тэгэхлээр бид троллуудаас хавьгүй их хүчтэй. Бид бол энэ дэлхийн яс нь гэсэн үг. Модны үндэс хаданд шигдэж ордгийг мэднэ биз дээ? Тэгэхдээ үндэс хадыг зуу зуун жилээр нүхэлж ордог бол бид шууд л нүхэлнэ, гэхдээ мэдээж уурлахаараа. Биднийг хөгшрөхөөр цавчиж унагаах юм уу шатааж, аливаа шидийн хараалаар унагааж болох л байх, харин бид хүсэх л юм бол тэр Изенгард мэтийг үнсэн товрог болгоно, ойлгов уу?

- Гэвч Саруман та нарыг гараа хумхиад харж суухгүй шүү дээ.

- Кгм, нээрэн тийм шүү, би энэ тухай мартаж орхиж. Гэхдээ үнэнийг хэлэхэд би энэ тухай л бодож байгаа. Би эдэн дотроо хамгийн хөгшин нь, бусад маань надаас хэдэн зуун жилээр залуу, тэдний дотор Изенгардыг газрын хөрснөөс арчина гэсэн ганцхан л бодол байгаа. Дараа нь жаахан бодож, умдаагаа уугаад тайвширна. Ээ дээ, бид ч унтахынхаа өмнө сайхан ууна даа! Харин одоохондоо эд маань дуулаад л алхаж байг! Хүрэх газар хол, бодох цаг зөндөө.

Тэгээд Модон онтуудынхаа дууг өмнөх шигээ оргилуун хоолойгоор түрлээ. Тэгснээ түүний дуу аажмаар намсч, духных нь үрчлээ бодолдоо гүнзгийрэн атриатав. Дараа нь харцаа дээш өргөхөд Пин түүний нүдэнд гацуудал илрэхийг харсан боловч цөхрөл харагдсангүй.

Харин ч ногоон гал нь бодлынх нь холоос улам л бадран дүрэлзэж байгаа үзэгдэв.

- Онтууд миний андууд, хувь заяа биднийг ивээн тэтгэж ч болно, хөсөр хаяж ч магадгүй, энэ бидний эцсийн аян дайн ч байж магадгүй юм. Гэвч бид орон гэртээ амар тайван суугаад байхыг эрхэмлэвэл хувь заяа биднийг өршөөхгүй, эрт орой хэзээ нэгэн цагт үзэх юманд эрт оройн ялгаа юу байна? Бид энэ талаар эртнээс бодож байсан учраас энэ аян дайнд хөдөлж байгаа юм. Бид яараагүй, зүгээр л шийдвэрээ боловсруулж байсан юм. Бидний энэ аян дайны тухай дуу зохиогдоно. Бид өөрсдөө үрэгдэж магадгүй, гэхдээ үлдэгсэддээ тусална. Нэг л гэм нь бид онтжингуудтайгаа уулзаж чадахгүй бол харамсалтай байна. Би Фимбретилийгээ дахин нэг харахыг мөн ч их хүсч байна даа. Гэхдээ андууд минь, дуу гэдэг чинь модтой л адил шүү дээ. Үр жимсээ цагт нь өгч ч чадна, цагаасаа түрүүлээд хатаж ч болно – гээд гүн санаа алдав.

Онтууд нэгэн хэмээр том том алхлан өмнө зүг рүү урт хөндийгөөр замнаснаа дараа нь баруун тийш огцом эргэж, Метхедрасын хяр руу улам улам дээшлэв. Ой шингэрсээр хаа нэгтээ бяцхан хусан төгөл, ганц нэг нарс сүглийж харагдана. Нар уулын цаагуур орлоо. Бүрэнхий болов.

Пин эргэж харав. Онтууд нэмэгдсэн юм уу... энэ чинь юу гээч болж байна аа? Тэдний араас ой нүүж байх мэт, модод тэдний араас нүүгэлтэн алхаж байна! Фангорн мөнхийн нойрноос сэрж, модон дайчдаа илгээж байгаа юм уу? Пин нүдээ арчив. Бүрэнхийд нүд бүрэлзсэн юм болов уу, зүүрмэглэсэн юм болов уу? Үгүй юм аа, тоо томшгүй олон мөчиртөө салхи шуугиуланхан ойн модод тэр чигээрээ араас нь тэп тап -тэп тап алхаж байна. Онтууд оргил дээр гараад дуулахаа зогсов.

Харанхуй болж, газар дэлхий ой модны лужир алхааг дааж ядах мэт үл мэдэг чичирхийлэн, мянга мянган навч мөчрийн сүрлэг шивнээн үргэлжилнэ. Уулан дээрээс тэртээ доор Манант уулсын захын оргил - Нан-Курунирын харанхуй хавцал, Саруманы хөндий харагдана.

- Изенгардыг шөнө нөмөрчээ – гэж Модон хэлэв.

Бүлэг 5

Цагаан морьтон

Мон ч хүйтэн байна даа, чөмөг царцаах нь - гэж Гимли хэлээд, шүдээ дагжин алгаа үрж, дороо дэвхцэв. Үүр цаймагц тэд хуурай хүнснээсээ идээд нар гарахыг хүлээв. Хоббитуудын мөр олдож юун магад.

- Тэр юун өвгөн юм бол? – тэрний мөрийг л олж харахыг би тун их хүсч байна!

- Түүгээр яах юм бэ? - гэж Леголас гайхав.

- Хэрэв газар дээгүүр явж байгаа бол тэр зүгээр л нэг өвгөн байгаа.

- Ийм хатуу, өндөр өвстэй газарт чи яаж мөр олох юм бэ?

- Мөрчид энэ бол саад биш, Арагорн гишгэгдсэн нэг ширхэг өвсийг ч олж харна. Харин сүг сүүдрүүд бол өөр хэрэг, тэдэнд мөр байдаггүй, Арагорн нэг ч мөр олохгүй бол бидэн дээр Саруманы сүүдэр ирсэн байна гэсэн үг. Шөнө ч бай, өглөө ч бай ялгаагүй. Одоо ч гэсэн тэр ойн захаас бидний араас харж байгаа биз.

- Тун ч магадгүй - гэж Арагорн зөвшөөрөөд - гэхдээ үгүй ч байж мэднэ. Гимли, чи морьдыг тэр үргээсэн гэж хэлсэн шүү дээ. Леголас, морьд ямар их айсан шинжтэй янцгааж байсныг чи сонсоо биз дээ?

- Маш тод сонссон. Гэхдээ морд огт айсан шинжтэй байгаагүй, бид л харанхуйд айсан, харин морьд хуучны сайн андтайгаа уулзсан юм шиг баяртай янцгааж байсан.

- Надад ч гэсэн тэгж санагдсан - гэж Арагорн өгүүлээд: - Яг юу болсныг морьд эргэж ирвэл мэднэ дээ. За за! Гэгээ орчихлоо, одоо нар мандана. Явж эрцгээе, бодохоо дараа нь бодъё! Бидний хоносон газар нь хэсэг ойн өмнөх налуу газар байна. Хоббитуудын мөрийг хайя, шөнийн гийчний асуудлыг тусад нь шийднэ. Хэрэв тэд ямар нэг гайхамшигт учралаас зугтааж чадсан бол тэр ойд л нуугдсан. Өөр нуугдах газар байхгүй. Эндээс ой хүртэл хайгаад юу ч олохгүй бол тулалдааны талбарыг нэгжиж, үнстэй хутгалдахаас. Тэнд ч олох найдвар муу даа. Ристанийн морьт дайчид ажлаа сайн мэддэг юм - гэв.

Тэд хавийн газрыг алхам алхмаар нэгжин мөр хайлаа. Арагорн голын дээрх харуулын галын үнс рүү дөхөж, сүүлчийн тулалдаан болсон уулыг дахин нэг эргэв. Тэр гэнэт бөхийж, нүүрээ бараг газарт хүргэн харлаа. Тэгээд Леголас, Гимли хоёрыг дуудахад цаад хоёр нь хар хурдаараа гүйж хүрэв.

- Эцсийн эцэст эрснээ оллоо! – гэж Арагорн хэлээд бага зэрэг гандаж шарласан, цайвар шаргал өнгөтэй, урагдсан навч үзүүлээд: - Лориэний мэллорны навч байна, навчин дээр болон дэргэд нь талхны үртэс асгарсан байна. Бас тасалсан хүлээс байна, харав уу?

- Хүлээсийг тас огтолсон хутга нь ч байна! - гээд Гимли үзүүрээр нь газар руу шаасан иржгэр иртэй хугархай хутга, түүний бариулыг гаргаж үзүүлэв: - Орх кинжал байна – гэж тэр хэлээд, сөлөр нүдтэй, жихүүдэс хүрэм муухай царай дүрсэлсэн бариулыг цээрлэнгүй харав.

- Энэ ч ёстой оньсогоны цаад оньсого байна даа! Хүлээстэй олзлогдогч орхуудаас зугтаад, Ристанийн морьт дайчдын соргог хараанаас мулгарч, байлдааны талбарт орхын хутгаар хүлээсээ тасалсан байдаг. Учрыг нь олохгүй байна. Хөл нь хүлээстэй юм бол яаж оргосон байх вэ? Гар нь хүлээстэй юм бол яаж хүлээсээ таслах вэ? Хүлээсгүй байсан юм бол энэ хутга, тасархай хүлээс юу вэ? Дөнгөж оргонгуутаа тайван суугаад хооллож байх уу. Хоббит гэдэг нь илэрхий, мэллорны навч ч байна. Миний ойлгож байгаагаар, дараа нь гар нь далавч болж хувираад ой руу дуу аялан нисч дээ. Араас нь нисээд ойгоос олох юухан байх вэ, даанч далавч алга байна даа – гэж Леголас өгүүлэв.

- Ид шидгүйгээр ийм юм болохгүй, даанч ойгоор тэр өвгөн тэнээд байсан юм аа. Арагорн минь, Леголас бараг бүгдийг тайлбарлачих шиг боллоо. Магадгүй, чи арай ойлгомжтой тайлбарлах юм уу?

- Оролдоод үзье. Та хоёр дутуу харж байна, яагаад гэвэл зарим нэг юмыг ойлгоогүй байна. Олзлогдогч хоббит гэдэг нь мэдээж, тэр хөлөө ч юм уу гараа ч юм уу урьдчилаад сулласан байна. Гараа л чөлөөлсөн гэж бодож байна, хоёрдугаарт түүнийг энд орх үүрч авчирсан байна. Энүүхэнд газар дээр хатсан хар цусны толбо байна. Эргэн тойронд морин туурайн гүн мөр байна. Орхыг морьт дайчид устгаад, хүүрийг нь бусадтай нь хамт шатаасан байна. Тулалдааны талбар дунд байсан хоббитыг анзаарсангүй, харанхуй байсан, хоббит эльф цувтай байсан. Үхдэл орхын кинжаалаар хүлээсээ тасалсан, тэр их өлссөн, ядарч туйлдсан тул түр амарч, хүчээ сэлбэсэн байна. Үүнд гайхах юм алга. Үүргэвч нь байгаагүй, путлибыг халаасандаа авч явжээ. Энэ бол хоббитын зан. Энд баярлах нэг юм байгаа нь би ганц тоон дээр яриад байгаа боловч хоёулаа аврагдсан гэж би найдаж бана.

- Нэг нь гараа сулласан байсан гэж би бодож байна уу? – гэж Гимли асуув.

- Мэдэхгүй ээ, орх яах гэж тэднийг авч зугтсаныг ч мэдэхгүй юм. Байзнаарай, би бүр эхнээсээ л намайг зовоогоод байсан нэг асуудлыг шийдчих шиг боллоо. Яагаад орхууд Боромирыг дийлээд Мерри, Пин хоёрыг авч зугтаасныг одоо би ойлгож эхлэх шиг боллоо. Тэд бусдыг нь хайгаагүй, бидний тээшийг аваагүй, шууд л Изенгард руу ум хумгүй арилсан. Бөгж хадгалагчийг үнэнч дагуултай нь бариад авлаа гэж бодсон байх. Гэвч үгүй л баймаар юм. Хар эзэд өөрсдөө сайн мэдэхгүй байгаа тийм чухал нууцыг орхуудад итгэж даалгамааргүй дээ. Орхуудад бөгжний талаар ил хэлж болохгүй, тэд найдваргүй боолууд. Зүгээр л хоббитуудыг ямар ч үнээр хамаагүй бариад амьдаар нь авчир гэж тушаасан. Шийдвэрлэх тулалдааны өмнө аль нэг орх үнэтэй хоббитуудыг авч оргоод, ганцаараа гарамгай баатар болох гэжээ. Тэд ийм юмандаа гарамгай. Би ингэж л бодож байна, өөрөөр ч байж магадгүй л дээ. Ямар ч гэсэн хоёр нөхөр маань, ядаж нэг нь зугтаж амжсан байна. Бид түүнийг олж аврах хэрэгтэй. Ингэхгүйгээр бид Ристани руу явахгүй.

- Юу намайг хамгийн ихээр айлгаж байгааг би мэдэхгүй байна. Фангорн уу, Ристани руу явган явах уу - гэж Гимли үглэв.

- Тэгвэл ой руу явъя л даа - гэж Арагорн хэллээ.

Удалгүй тэд дахиад хоббитуудын шинэ мөрийг олов. Онтавагийн эрэг дээр, аварга том модны ёроолд тэр мөр дөнгөж мэдэгдэх төдий байв.

- Нэг хоббит яг энд зогсоод эргэн тойрноо харж байснаа ой руу гүйсэн байна - гэж Арагорн итгэлтэй хэллээ.

- Тэгэхлээр бид ойд орохоос гарцаагүй болж байна – хэмээн Гимли санаа алдаад: - Ёохх, энэ Фангорн надад ёстой таалагдахгүй байна. Тэдний хойноос явмаар л байна, гэхдээ тийшээ л биш.

- Харин би энэ ойг муу ёр шүглэсэн ой гэж бодохгүй байна, ой надад айдас төрүүлэхгүй байна - гэж Леголас бодлогошронгүй хэлэв. Тэр ойн захад бөхийсхийн зогсоод, бүрэнхий шугуй руу ширтэж байснаа - энд ямар ч муу ёр үнэртэхгүй байна, гэхдээ алсаас заналхийлсэн цуурай сулхан сонсдож байна, бодвол ойн гүнд хаа нэгтээ өмхөрсөн зүрхтэй хөгшин моднууд тааламжгүй санаа сэдэж байгаа биз. Гэхдээ ойр хавьд ямар ч муу муухай юм алга байна, зүгээр л ой тэр чигтээ түгшүүрт авгаж уурласан байна гэв.

- Тэр надад юундаа уурладаг юм бэ? – би тэрэнд туу юм хийгээгүй – гэж Гимли гүвтнэв.

- Тийм л дээ. Гэхдээ тэр чамгүйгээр их зовлон үзсэн байна. Бас... энэ ойд ямар нэг юм болж байна, эсвэл болох гэж байна. Эргэн тойронд бүх юм нам гүм байгааг мэдэрч байна уу? Амьсгал ч давчдаж байна.

- Тийм ээ, бүгчим байна. Танай Бөглүүд ойд гүн орох тусам агаар дутагдмал байдаг, гэхдээ эндхийнх шиг ийм бүгчим биш, модод нь ийм үхмэл биш.

- Эртний ой, асар эртний ой – гэж эльф хэлээд - би бүр залуужсан юм шиг санагдлаа. Гэтэл та нар шиг хүүхдүүдийн дэргэд би балар эртний ойн манаач өвгөн шүү дээ. Эртний ой бол ой дуртгалын сан. Дайн болоогүйсэн бол би энд зугаалаад л баясч явмаар байна.

- Чиний хувьд тэгэлгүй яахав - хэмээн Гимли дургүйхэн өгүүлээд: - Чи бол ямар ч гэсэн ойн эльф, гэлээ ч гэсэн чи сэтгэлийг минь сэргээлээ. Одоо яая гэхэв, чи хаашаа – би тийшээ. Чи нум сумаа бэлэн авч яв, би ч сүхээ байлдаанд авлаа. Харин моднууд л битгий уурлаасай, би тэднийг хуруугаараа ч хөндөхгүй. Нөгөө өвгөн л биднийг отоож байгаад гэнэт дайрахгүй бол сайн байна. Явцгаая!

Леголас, Гимли хоёр Арагорны араас хоцролгүй дагаж, Арагорн хуурай мөчир, навчсыг цээжээрээ яран урагшилж байв. “Оргодлууд ус руу л ойртохыг хичээнэ” гэж тэр бодоод Онтавагийн эргээс холдолгүй явсаар Мерри, Пин хоёр ханатлаа ус ууж, хөлөө угаахдаа үзсэн том жижиг хоёр тод мөрөн дээр буув.

Сайхан мэдээ байна даа, гэхдээ гурван жилийн өмнөх мөр байна, хоббитууд энэ мөрийг үзээд голоос холдсон юм шиг байна - гэж Арагорн хэлэв

- Тэгээд одоо яах болж байна? Фангорны ойг бүхэлд нь самнах уу? Хүнсний нөөц бага байна. Хоббитууд долоо хоногийн дараа олдлоо гэхэд бид нөхөрлөлийнхөө төлөө бөөгнөж суугаад нүд аних байх даа – гэж Гимли хэлэв.

- Ядаж хамтдаа нүдээ анья, юу нь муу байхав. Урагшаа!

Төдөлгүй тэд Модонгийн уулын хясаанд дөхөж ирээд, чулуугаар тавьсан шатыг өлийн харав. Түргэн нүүж байгаа үүлэн завсраар нар гийж, дүнсгэр ойн өнгийг заслаа.

- Дээш гарцгаая, эргэн тойрныг харъя. Амьсгалахад бэрх байна, тэнд агаар нь цэнгэг байгаа – гэж Леголас санал гаргалаа.

Арагорн нөхдөө урдаа оруулаад чулуун гишгүүрүүдийг анхааралтай ажиглан араас нь өгслөө.

- Хоббитууд энд ирсэн гэдэгт би бараг итгэлтэй байна. Гэхдээ тэр хоёрын мөр алга байна, хэн нэгний хачин мөр байна. Ёстой ухаан хүршгүй мөр байна. За яахав, эргэн тойрноо сайн харъя, нэг юм олж үзэх ч магадгүй – гэж тэр хэллээ.

Тэгээд нуруугаа эгцлэн зогсч, хавь ойрыг нэгд нэггүй нэгжин харав. Хясаа зүүн өмнө зүг рүү харсан, хараа сайтай ажээ. Гэвч хөндий рүү ногоон сааралтан түрж орсон моддын оройноос өөр юм харагдсангүй.

- Бид их тойруу замаар ирж дээ. Хоёр дахь юм уу, гурав дахь өдрөө Их мөрнөөс баруун тийш эргэсэн бол аль эрт ганц хоногийн дотор ирчих байж. Хаагуур явах байснаа ирсэн хойноо л мэддэг хойно одоо яая гэхэв дээ – гэж Леголас харамсангуй өгүүлэв.

- Бид Фангорн руу ердөө явах хэрэггүй байсан юм - гэж Гимли зөрөв.

- Бид энд шувуу торонд өөрөө нисээд ордог шиг л ирлээ. Хараач!

- Хаашаа харах гэж?

- Тийшээ, тэр шугуй руу.

- Чи эльф нүдээрээ тэнд юу олж харав?

- Аяархан ярь гэм! Бидний явж ирсэн шугуй дундах жим рүү хар... Тэр мөн байна. Моднуудын дундуур зүтгэж байгаа харж байна уу.

- Аа, одоо харлаа! – хэмээн Гимли шивнээд: - Хараач, Арагорн! Би чамд хэлээ биз дээ? Нөгөө өвгөн чинь бохир саарал малгайтайгаа явж байна, тэгээд л би шууд харсангүй л дээ.

Арагорн бөгтийн алхаж яваа өвгөн рүү анхааралтай ширтэв. Тэр уулын бэлээр ойгоос гарч ирлээ. Харахад хөгшин гуйлгачин шиг, мөчир тулж, толгойгоо бөхийн хаашаа ч харалгүй арай ядан алхана. Өөр газарт бол тэд түүнийг дуудаж, мэндийн үг хэлэх байлаа, харин одоо ямар нэг бүдэг, эзэрхэг аюул мэдрэн учраа ч олохгүй хүлээж зогсов. Бөгтөр өвгөн алхам алхмаар ойртож байгааг Гимли нүдээ бүлтийлгэн ширтэж байснаа эцэст нь тэвчээр алдаж:

- Нумаа ав, Леголас! Онил! Энэ Саруман байна. Ам нээх боломж бүү өг, тэгэхгүй бол илбэднэ! Шууд харва!

Леголас нумын хөвчөө хэн нэгний тушаалыг зөрчиж байгаа мэт удаанаар татаад саадагнаасаа нэг сум дуртай дургүй авсан боловч хараалсангүй.

- Чи юугаа хүлээгээд байгаа юм бэ? Чи яачихаад байгаа юм бэ? - гэж Гимли тэчъяадан шивнэв.

- Леголасын зөв – гэж Арагорн тайван өгүүлээд: - Бид юунаас ч айж, юуг ч сэжиглэж байлаа гэсэн ядарсан өвгөнийг учир утгагүй, шалтгаангүй алж болохгүй. Хүлээе, харья!

Энэ хооронд өвгөн гэнэт алхаагаа хурдасган, чулуун шатны доор яах ийхийн зуургүй ирээд, дээш өлийн харж, үг дуугүй зогсч байгаа тэр гурвыг үзсэн боловч авиа ч гаргасангүй.

Түүний нүүрийг өргөн хүрээтэй бүрх малгайгаар дарж өмссөн алчуур хааж, зөвхөн хамрын үзүүр, буурал сахал нь л харагдаж байв. Гэвч үл үзэгдэх хөмсгөн дороос нь хурц нүд цоо ширтэх шиг Арагорнд санагдав.

Өвгөн нам гүм байдлыг эвдлээ:

- Өглөөний мэнд, найзууд аа! – хэмээн тэр аяархан дуугараад - Би та нартай ярилцвал сайн юмсан. Та нар наашаа бууж ирэх үү, би дээшээ өгсөх үү? – гэснээ хариу хүлээлгүй дээш өгсөв.

- Хурдлаач! Тэрнийг харваад өгөөч Леголас! – гэж Гимли сандрав.

- Би та нартай ярилцвал сайн юмсан гэж хэлсэн шүү дээ. Нумаа тайван байлга эрхэм эльф минь!

Нум сум хоёр Леголасын гараас мултарч, гар нь доош буув.

- Харин эрхэм гном минь, нинжин сэтгэл гарга, сүхээ бүү шүүрээрэй! Тэр одоохондоо чамд хэрэг болохгүй.

Гимли цочисхийж, баримал шиг хөдөлгөөнгүй зогсов. Өвгөний үхээнц байдал ор мөргүй алга болж, гишгүүрүүдээр янгир мэт дүүлэн хясаан дээр гарч ирэв. Хоромхон зуурт түүний өгөршсөн бохир хувцсан доороос нил цагаан гэрэл гийх шиг болов. Гимли шүднийхээ завсраар агаар исгэртэл татах нь нам гүмд тод дуулав.

- Давтан хэлье, өглөөний мэнд! – гэж өвгөн тэдэн рүү ойртон ирээд хэлэв. Хэдэн алхмын цаана тэр таяган дээрээ хүндээр даран зогсоод, хүзүүгээ сунган, далдалсан нүдээрээ тэр гурвыг нэгд нэггүй ажиглангаа: - Энэ хязгаарт та нарыг юу дуудаж авчраа вэ? Эльф, хүн, гном гурав – бүгдээрээ эльф хувцастай! Энэ газарт ийм сонин юм олон үзэхгүй шүү. Магад та нарт ярих юм байгаа даа.

- Чиний ярианаас үзэхэд, чи Фангорныг сайн мэддэг юм аа? – гэж

Арагорн хариу асуув.

- Юун сайн мэдэх! Зуу дахин амьдарсан ч энэ ойг сайн мэдэхэд хүрэлцэхгүй. Гэхдээ би хааяа хааяа үүгээр явдаг юм аа.

- Чи нэрээ хэлбэл ямар вэ, тэгээд бид яриаг чинь сонсьё? Өдөр болох нь, бид яарч явна - гэж Арагорн санал тавилаа.

- Миний үгийг та нар сая сонссон. Та нарыг юу нааш нь дуудав, энд юу хийж яваа юм бэ гэж би асуусан шүү дээ. Миний нэр үү!..

Өвгөн удаанаар аяархан инээв. Арагорны судсаар хүйт гүйх шиг болж цочин давхийв, гэвч энэ бол айдсын хүйт биш байлаа. Тэр хамаг биеийг сэргээсэн хүйтэн агаар залгих мэт, нойрмог нүүр рүү бороон дуслууд шавших шиг болоод явчихлаа.

- Миний нэр үү! – хэмээн өвгөн инээж дуусаад давтсанаа: - Та нар хараахан таагаагүй л байна уу? Та нар сонсч байсан шиг санагдаж байна. Тийм ээ, сонсч байсан. Тэгснээс ямар хувь заяагаар энд шидэгдсэнээ хэлсэн нь дээр дээ.

Нөгөө гурвын хэн нь ч дуугарсангүй.

- Тэгэхлээр таагүй юм хийж яваа юм байна гэж бодож болох л юм байна. Гэхдээ аз болоход тэдний талаар би бага сага юм мэднэ. Та нар хоёр залуу хоббитын мөрөөр явж байгаа шиг санагдаж байна. Тийм биз? Тийм ээ, хоббитууд. Ийм үг анх удаа сонсч байгаа юм шиг царай битгий гаргаарай даа. Та нар ийм үг урьд нь сонсч байсан, би ч гэсэн. Тэр хоббитууд уржигдар яг энд зогсч байсан, тэгээд... хэн болохыг нь ёстой, бүү мэд нэгэн этгээдтэй уулзсан. Сонсоход сонин байгаа биз? Эсвэл та нар дараа нь тэд эндээс хаашаа явсныг мэдмээр байна уу? За за, мэдэж байгаа юмаа хэлж өгье. Ингэхэд бид яагаад зогсоод байгаа билээ? Та нар бодож байгаа шигээ тийм ч их яараагүй. Алив сууцгаая, ярьж хөөрье.

Өвгөн эргэж, бөөн чулуу руу очоод, эгц өндөр хясааны ирмэг дээр зогсов. Илбийн үзүүлбэр дууссан юм шиг нөгөө гурав ч ухасхийв. Гимли сүхнийхээ бариулаас шүүрч, Арагорн илдээ сугалж, Леголас нум сумаа онилов.

Өвгөн энэ бүхнийг анзаараагүй юм шиг багавтар чулуун дээр суухад түүний үжиршсэн цув тайлагдаж, цав цагаан өмсгөл нь мэлсхийв.

- Саруман! – хэмээн Гимли хашгираад, сүхээ далайн үсэрч хүрэв:

- Ярь! Манай найз нарыг хааш нь нууснаа хэл? Тэд нарыг яасан бэ? Хурдан хэл, ид шидээр аврагдахгүй шүү. Би чиний гавлыг малгайтай нь хоёр хуваана!

Гэвч өвгөн түүнээс урьтлаа. Тэр үсрэн босч ганцхан үсрээд хясааны орой дээр зогсоод нүд ирмэх зуурт нүд гялбуулсан цагаан багана мэт асар өндөр болов. Цагаан өмсгөл нь гялалзаж, таягаа өргөхөд Гимлийн сүх чулуун дээр хангинан унав. Арагорны илд түүний үл чичрэх гарт очис цацруулан гэрэлтэв. Леголас чанга хашгирч, тавьсан сум нь цахилгаан цахиулан тэнгэр

өөд цойллоо.

- Митрандир! – хэмээн Леголас хашгирав: - Энэ чинь Митрандир байна шүү дээ!

- Дахиад хэлье. Өглөөний мэнд Леголас!

Өвгөний өтгөн үс оргилын цас мэт гялалзан, цагаан өмсгөл нь гэрэл цацруулж, саглагар хөмсгөн дороос цоглог нүд нь тод гялалзан, өргөсөн гар нь хүчирхэг үзэгдэв. Мэл гайхаж, айж, баярласандаа мань гурав газарт хадаатай юм шиг болж, дуугарч чадахгүй байлаа.

Эцэст нь Арагорн хэл орж:

- Гэндальф! – хэмээн хашгираад: - Бидний цөхрөх цагт чи эргэж ирлээ гэж үү? Би яахаараа чамайг таньдаггүй байна аа, Гэндальф!

Гимли үг дуугүй газарт унаад, алгаараа нүүрээ дарав.

- Гэндальф – гэж өвгөн аль эрт мартагдсан нэрээ санах мэт – нээрэн намайг ингэж дууддаг байсан. Би Гэндальф байсан.

Тэр хясаан дээрээс буун ирж, газар хаясан навтасаа авч дахин нөмрөхөд мандсан нар үүлэн цаагуур орох мэт болов.

- Тийм ээ, урьдынх шигээ намайг Гэндальф гэж дуудаж болно – гэж тэр хэлэхэд дуу хоолой нь урьдын адил анд нөхөр, багшийн дуу мөн байлаа.

- Бос доо, миний сайхан сэтгэлт Гимли минь! Чамд буруу байхгүй, чи надад хор хүргээгүй. Үнэнийг хэлэхэд чадаагүй. Та нарын зэвсэг надад хоргүй. Бид энэ оволзсон давалгаан дээр дахиад уулзлаа. Их шуурга болно, гэхдээ энэ давалгаа намжина - гээд тэр Гимлийн толгой дээр гараа тавихад цаадах нь толгойгоо өргөснөө гэнэт тачигнатал инээв;

- Гэндальф яг мөн байна! Гэвч яагаад ийм цагаан өмсгөлтэй байгаа юм бэ?

- Одоо би цагаан өмсгөлтөн болсон. Одоо би Саруман гэж хэлсэн ч болно, тэр ямар байх ёстой байсан, би тийм болсон. Гэвч энэ тухай дараа ярья, өөрсдийнхөө тухай ярь! Би та нарын мэддэг тэр Гэндальф биш болсон, би хар галд шатсан, газар доорх мөсөн усанд хахаж цацсан. Урьд нь мэдэж байсан олон юмыг мартсан, мартсан олон юмаа санасан. Би алсыг тов тод харж байна, харин ойрын юмс бүдэг бадаг байна. Өөрсдийнхөө тухай ярь!

- Чи юу мэдмээр байна? Бид Моригоос гарснаас хойш өчнөөн үйл явдал болсон. Энэ бол урт түүх. Эхлээд хоббитуудын тухай ярьж өг - чи тэднийг олсон уу, тэд амьд мэнд үү?

- Үгүй ээ, би тэднийг олоогүй, эрээ ч үгүй – гээд Гэндальф толгой сэгсэрч: - Дайсны хөндий мананд хучигдсан байсан, тэднийг олзолсон гэж би мэдээгүй, надад бүргэд энэ тухай хэлсэн.

- Бүргэд ээ! - хэмээн Леголас дуу алдаад - Би түүнийг алсын өндөрт харсан: сүүлийн удаа Дайсны хөндийд, дөрөв дэх өдөр.

- Тэр бол Гваигир Салхин жигүүр байсан юм, намайг Ортханкаас аварсан бүргэд. Би түүнийг тагнуулд явуулж, Их мөрний орчинг тандан мэдээ авчир гэсэн юм. Бөглүү ой, хонхор хотгорт олон юм бүргэдийн нүдэнд харагдаагүй, тэр болгоныг би өөрөө явж мэдсэн. Бөгж хадгалагч хол явсан, түүнд би ч, та нар ч одоогоор тусалж чадахгүй. Хар эзэн бүхнийг эзэмдэх зэвсгээ хариугүй олчих шахсан, гэвч тийм юм болоогүй, би үүлэн цаадах өндрөөс тэрний нугаршгүй хүчинд саад болж, бөгжнөөс холдуулсан. Хар сүүдэр хажуугаар нисч өнгөрсөн. Гэвч би тэгэхэд хүч алдан туйлдаж, дараа нь удаан зовж байж сэргэсэн.

- Тэгвэл чи Фродогийн талаар бүгдийг мэдэж байх нь ээ – хэмээн Гимли баярлаж: - Тэр одоо хаа байна, түүнд юу тохиолдсон бэ?

- Энийг би мэдэхгүй. Тэр аймшигт аюулаас амьд гарсан, гэвч өмнө бүр ч аймшигтай бусад аюул байгаа. Тэр цор ганцаараа Мордор явахаар шийдэж, замдаа гарсан, үүнээс өөр надад мэдэх юм алга.

- Цор ганцаараа биш ээ, Сэм дагаад явчихсан юм шиг байна лээ – гэж Леголас хэлэв.

- Хараач хөөе! – гээд Гэндальф инээмсэглэн нүд нь гялалзаж: - Дагаад явчихсан юм биз дээ? Энэ чинь надад мэдээ байна, гэхдээ урьдаас мэдэж байсан л даа. Сайн байна! Санаа амарлаа. Сууцгаа, өөрсдийнхөө адал явдлын тухай ярьцгаа.

Найзууд түүнийг тойрон сууж, Арагорн ярилаа. Гэндальф нүдээ анин, гараа өвдөг дээрээ тавиад, асуулт тавилгүй удаан дуугүй сонсов.

Арагорн Боромир тулалдаанд унасан тухай, түүний шарилыг Их мөрнөөр урсгасан тухай ярихад өвгөн гүн сана алдав:

- Чи мэдэж байгаа юм уу, таамаглаж байгаа зүйлээ бүгдийг хэлсэнгүй, Арагорн анд минь – гэж тэр зөөлөн хэлээд: - Хөөрхий Боромир минь дээ! Түүнд юу тохиолдсон юм бол гэж би гайхаад байсан юм. Сурвалжит ван, төрөлхийн жанжин тэр хүнд хүнд сорилт тулгарч дээ. Тэрэнд нэг юм тохиолдлоо гэж Галадриэль надад ярьсан юм. Гэвч тэр өөрийгөө ялж, нэр төрөө аварч, алдар хүндийг оллоо. Тэгэхлээр бид залуу хоббитуудыг авч явсан нь талаар болсонгүй. Зөвхөн Боромирын төлөө авч явсан ч харамсах юмгүй байж. Үнэндээ зөвхөн түүний төлөө ч биш, орхууд тэднийг Фангорн хүртэл чирэхдээ өөрсөндөө гай уджээ... тийм дээ, жижиг чулуунууд уулын нургийг үүсгэдэг юм. Их нургийн алсын чимээ одоо ч сонсдож байна. Саруман энэ нургаас цайзынхаа хананд нуугдаж амжихгүй бол хохь нь болно доо!

- Нэг л юман дээр чи өөрчлөгдсөнгүй анд минь, нөгөө л оньсого таавраар ярьдаг чинь хэвээрээ байна - гэж Арагорн хэлэв.

- Тийм үү? - гэж Гэндальф гайхсанаа - үгүй дээ, би зүгээр л өөртэйгээ ярьж байна. Хөгшин хүний зан шүү дээ. Мэргэн хүнтэй ярь, залууст хэтэрхий удаан тайлбарлах хэрэг гарна гэж өвгөд боддог юм.

Тэр инээхэд инээд нь нарны дулаан гэрэл мэт ээнэгхэн байлаа.

- Намайг залуу гэх аргагүй, эртний хаадтай зүйрлэсэн ч би хөгшин. Чи тайлбарлахыг оролд, би ойлгохыг хичээе.

- Гурвууланд нь ойлгомжтойгоор би яаж тайлбарлах болж байна? -

гээд Гэндалф бодолхийлснээ - За яахав, оролдоод үзье, товчхон бөгөөд аль болохоор энгийнээр. Дайсан бөгж бидний гарт орсныг, түүнийг хоббитод итгэж даалгасныг аль эрт мэдсэн байна. Бид хэдүүлээ Уудам хөндийгөөс аян замд гарсан, хэн хэн яваа, хэн нь хэн бэ гэдгийг ч мэдсэн. Одоохондоо тэр бидний зорилгыг л мэдэхгүй байгаа. Тэр биднийг бүгдээрээ Минас-Тирит рүү явсан гэж бодож байгаа, учир нь тэр бидний оронд байсан бол тэгэх л байсан. Тэгээд дайсныхаа хүчийг бутраан бусниулж багасгах мэргэн шийд гаргах байсан. Одоо тэр бөгж зүүсэн үл мэдэх агуу хүчирхэг дайсан тэрний хаанчлалыг үгүй болгож, хар ширээнд нь хаан суухаар гэнэт гараад ирнэ гэхээс амиа гартал айж байгаа. Бид тэрнийг устгахын тулд бөгжийг устгах гэж байгаа болохоос тэрнийг орлох гэж байгаа биш гэдэг тэрний ухаанаас давсан зүйл. Бид бөгжийг устгах зорилготой гэдэг тэрний хамгийн аймшигт зүүдэнд ч орохгүй. Бидний ялалтын хэврэгхэн баталгаа, найдварын маань сулхан үндэс энэ л байна. Тиймээс тэр үл мэдэх дайснаасаа урьтахын тулд дайныг даруй эхлэхээр яарч байгаа. Хэрэв эхний цохилт үхлийн цохилт болбол хоёр дахь цохилт хэрэггүй. Ингээд л аль эртнээс нууцаар бэлдсэн их хүчээ төлөвлөсөн цагаасаа өмнө хөдөлгөж байгаа юм. Мэргэн тэнэг!

Хэрэв тэр бүх хүчээрээ Мордорыг хамгаалж, тийшээ ялаа ч нисч орохооргүй болгоод, бөгжний араас бүх арга хэрэгслээрээ хөөцөлдсөн бол бидэнд ямар ч найдвар байхгүй байх байлаа. Бөгжний тусламжаар тэр хадгалагчийг амархан олж болох байсан. Гэвч тэрний нүд Мордороос гадуур тэнэж, Минас-Тирит рүү шөвөгдөж байна. Тун удахгүй Гондор руу аймшигт аянга буулгана. Яагаад гэвэл хадгалагчийг амдаж явуулсан тагнуулчид нь ор мөргүй алга болсныг тэр мэдэж байгаа. Бөгж олдоогүй. Олзлогдсон хоббитуудыг тэрэнд авчирч өгөөгүй. Хэрэв хоббитуудыг аваачаад өгчихсөн бол бидний хувь заяа хялгасан дээр дүүжигнэх байсан. Манай багачуудыг хар цайзын ханан дотор аймшигтайгаар тамлаад нууцыг хэлүүлнэ гэж сэтгэл зүрхээ шаналгах хэрэггүй. Одоохондоо Дайсны төлөвлөгөө тасалдлаа. Саруманы ачаар шүү дээ.

- Тэгвэл Саруман урвагч биш юм уу? - гэж Гимли гайхав.

- Мэдээж урвагч, - гэж Гэндалф хариулаад: - Хоёр давхар урвагч. Гайхалтай биш гэж үү! Бидэнд саяхан тохиолдсон гай зовлонгуудаас хамгийн гашуун нь Саруманы урвалт байлаа. Дээр нь тэр эзэн захирагч, жанжин болоод асар их хүч хуримтлуулсан. Тэр Мустангримыг эзлэхээр заналхийлж, үүнээс болоод мустангримчүүд дорноос ирэх аюулаас хамгаалахын тулд Минас-Тирит рүү тусламж илгээж чадахгүй байна. Гэвч урвагч ямагт өөртөө дүүжлүүр бэлдэж байдаг юм.

Саруман бөгжийг гартаа оруулах, наанадаж хоббитуудыг барьж аваад бүх нууцыг мэдэж авах гэж мөрөөдсөн. Саурон тэр хоёр санаа нийлсэн бол ердөө л Мерри, Пин хоёрыг Фангорнд даруйхан авчрах хэрэгтэй байсан, гэтэл тэр хоёр яг цагаа олоод бусад үед яагаад ч очихгүй байсан тэр газарт хүрээд ирчихсэн!

Бие биеэ сэжиглэж байгаа учраас тэдний төлөвлөгөө будилж байна. Ойн захад болсон тулалдааны тухай Мордорт ямар ч мэдээ очоогүй байгаа. Тэгсэн мөртөө хоёр хоббитыг олзлоод Хар эзний зарлигийг зөрчин Изенгард руу авч явсан тухай мэдээ хүрсэн. Ристанийн морьт дайчдад баярлахаас өөр яах билээ бид. Одоо хар эзэн Минас-Тирит дээр нэмээд Изенгардаас болгоомжлох хэрэгтэй боллоо. Хэрэв Минас-Тирит унавал Саруманд тун ч эвгүй юм болно.

- Тэднийг өөр хоорондоо уралцахад хоёр найз маань өөрөө мэдэлгүй саад болж байгаа нь харамсалтай. Изенгард Мордор хоёр хоорондоо байлдаж, бидэнд хүч нь суларсан ялагчтай нь тулалдахад хялбар болох сон – гэж Гимли хэлэв.

- Ялсан талынх нь хүч хоёр дахин нэмэгдэх байсан, эргэлзээ алга болох байсан. Тэгээд ч Изенгард яаж Мордортой байлдах вэ дээ. Саруман бөгжийг хуруундаа угладаггүй л юм бол. Одоо тэрэнд ийм аюул байхгүй болсон. Тэр ямар дүүжлүүрийн гогцоонд орсноо өөрөө ч мэдэхгүй байгаа. Ер нь тэр олон юм мэдэхгүй. Тэр олзоо шүүрч авахаар яарч, байж сууж чадахаа болиод өөрөө тагнуулчдаа угтаж гарсан. Гэвч хожимдсон. Тэрний галзуу саарал армиас үнс л үлдлээ. Тэр энэ хавиар удаан тэнээгүй. Тэрний эргэлзээ, хорон санаа надад инээд хүрмээр ойлгомжтой байгаа. Ойн ухааныг тэр мэдэхгүй. Юун Фангорн! Тэр морьт дайчид бүгдийг ямар ч сонголтгүй хядаад бүх хүүрийг нь шатаасан гэж бодож байгаа орхуудтай хоббитууд явсан эсэхийг тэр мэдэхгүй. Тэр өөрийнх нь явуулсан орхууд Мордороос явуулсан орхуудтай уралцсаныг ч мэдээгүй, далавчит сүгний тухай ч мэдээгүй.

- Бас ямар далавчит сүг билээ! – хэмээн Леголас хэлээд: - Би тэрнийг ууланд лориэний нумаар харвасан. Тэр усанд унасан. Тэр биднийг их айлгасан шүү. Тэр ямар гээч мангас байсан юм бэ?

- Тэр мангасыг сумаар дийлэхгүй. Чи тэрнийг унаагүй болгосон. Их сайн. Гэвч тэр дахиад унаатай болсон. Тэр бол есөн бөгжтөний нэг, одоо тэд далавчит мангас хөлөглөдөг болсон. Мөдхөн тэдгээр урьд өмнө байгаагүй мангаснууд өрнөдийн дайчдын дээгүүр хар үүл мэт тэнгэрийг бүрхэн манай дайчдын зүрхийг айдсаар царцаана. Гэхдээ одоохондоо тэдэнд их мөрнөөс цааш нисэх даалгавар өгөөгүй, Саруман ч бөгжний шинэ эзэн хэн болохыг мэдээгүй. Тэрний санаанд бөгжнөөс өөр юм байхгүй байгаа. Байлдааны талбараас хэн нэгэн нь түүнийг олбол яана? Хэрэв Мустангримын эзэн захирагч Теодений гарт орвол яах бол, хэрэв тэр бөгжний учрыг таньж мэдээд түүнийг ашиглаж чадвал яана. Ийм бодол Саруманыг бүхнээс илүү айлгаж байгаа учир тэр Изенгард руу яаран эргэж, Ристани руу дайрах хүчийг хоёр гурав дахин нэмэгдүүлэхийг чармайж байна. Гэтэл түүний хувьд аюул тэнд байгаа биш юм шүү дээ, тэр Модонгийн тухай бодохоо ч мартсан.

- Чи дахиад л өөртэйгээ ярьж эхэллээ – гээд Арагорн инээмсэглэж: - Модон гэж хэн юм бэ, би мэдэхгүй. Саруман давхар урвасан тухай би таамаглаж байсан, гэвч хувь заяа хоббитуудыг Фангорн руу шидэж, бид хөлийн хурдаар хэд хоног хий дэмий гүйж, цаг алдсаны буруу гэж юу байх билээ?

- Байзаарай, байзаарай! – хэмээн Гимли яриаг нь таслаад: - би эхлээд өөр нэг юм асуугаадахъя. Өчигдөр орой ойн захад бидэн дээр Гэндальф чи ирсэн үү, эсвэл Саруман уу?

- Өчигдөр би тэнд байгаагүй, тэгэхээр та нар Саруманыг харсан байна. Бид хоёр дэндүү адилхан болохоор л чи миний муу малгайг хоёр хуваах гэсэн байна шүү дээ.

- Ашгүй дээ! - Чи байгаагүй нь яамай.

- Тэгэлгүй яахав, эрхэм гном минь, - хэмээн Гэндальф дахин инээж: - Ядаж зарим нэг юман дээр алдахгүй байх аятайхан. Би үүнийг мэдэлгүй яахав. Тийм найрсаг угтсанд чинь намайг гомдсон гэж бүү бодоорой. Би найз нартаа өөрийнхөө сүүдрээс ч болгоомжилж яв гэж хэлдэггүй байсан гэж үү? Тийм учраас Глоины хүү Гимли чамаар бахархаж байна! Магадгүй нэгэн цагт чи намайг Сарумантай зэрэгцүүлж харж магадгүй, тэгвэл өөрөө ялгаж таних болно.

- Хоббитуудын тухай ярьж байгаа шүү дээ! - гэж Леголас сануулаад:

- Бид тэр хоёрын хойноос байдаг хурдаараа энд гүйж ирсэн, гэтэл чи тэднийг хаана байгааг нь мэдэж байгаа юм шиг байна. Хаана байгааг нь хэлээч!

- Тэнд, Модон болоод бусад онтуудтай хамт - гэж Гэндальф хариулв.

- Онтууд гэнэ ээ! - хэмээн Арагорн асуугаад: - тэгэхлээр ойн гүн дэх мод манагч аварга биетнүүдийн тухай хуучны домог үнэн байх нь ээ? Нарт ертөнцөд одоо онтууд байсаар байгаа юм уу? Гэтэл би өнгөрсөн үеийн үлгэр юм уу, ристанийнхны зохиосон цуурхал гэж бодож байсан шүү.

- Ристанийнхан гэнэ ээ! - гэж Леголас дуу алдаад: - Бөглүүд ойн ямар ч эльф онтуудын хагацлын тухай гунигт дууг мэддэг юм! Гэхдээ бүр бидэнд хүртэл энэ бол эртний домог шиг санагддаг. Хэрэв би амьд онт үзэх юм бол үнэхээр залуужна! Гэхдээ “Модон” гэдэг чинь нийтийн хэлээр “Фангорн” гэсэн үг, гэтэл чи ойн тухай яриагүй шүү дээ. Модон гэж хэн юм бэ?

- Хэцүүхэн асуулт байна. Би түүний тухай тун бага мэднэ. Гэвч яриад хэлбэл дуусахгүй түүх болно. Модон бол эндхийн ойн ерөнхий хамгаалагч, Газар дундын эртний оршин суугч. Леголас, чи түүнтэй уулзаж магадгүй юм. Харин Мерри, Пин хоёрт аз тохиосон. Тэр хоёр яг бидний сууж байгаа энэ газар түүнтэй тааралдсан юм. Тэр манай хоёрыг ойн нөгөө тал руу гэр рүүгээ авч яваад яг гурав хонож байна. Тэр наашаа хааяа хааяа ирдэг юм. Би түүнийг дөрөв хоногийн өмнө энд харсан, тэр ойгоор хэсч явсан, намайг ч харсан, бүр зогссон, гэвч би түүнтэй ярилцаагүй. Би Мордорын нүдтэй халз тулалдаад их ядарч, таагүй бодолд дарагдсан байсан. Тэр ч дуугараагүй, намайг ч дуудаагүй.

- Тэр бас л чамайг Саруман гэж бодсон байх. Гэвч чи тэр Модонгийн талаар найз юм шиг л яриад байх юм, тэрнээс болгоомжлох ёстой юм биш үү? - гэж Гимли асуув.

- Болгоомжлох! – хэмээн Гэндальф мушилзаад: - Надаас ч гэсэн болгоомжлох хэрэгтэй. Надаас аюултай хэнийг ч чи амьдралдаа үзэхгүй, чамайг амьдаар чинь Хар эзний хөлд чирээд очиж ч магадгүй. Арагорноос ч, Леголасаас ч болгоомжлох хэрэгтэй, Глоин хүү Гимли минь. Чамаас ч гэсэн бусад чинь болгоомжилж байг! Мэдээж, Фангорн-Ой аюултай –

ялангуяа сүх далайгчдад бүр ч аюултай, ойн хамгаалагч Фангорн ч аюултай, гэхдээ мэргэн ухаан, сайхан сэтгэлээр хэн ч түүнийг давахгүй. Түүний гомдол олон зуунаар зузаарсан, тэвчээр нь барагдсан, тиймээс ой тэр даяараа хилэгнэж байна. Хоббитууд энд бөөн мэдээ авчирч, ой тэр чигээрээ Саруманд, Изенгардын мод цавчигчдад хилэгнэж байна. Одоо ертөнцийн эхний өдрөөс хойш үзэгдээгүй юм болно. Номхон онтууд түрхрэн босч, хэмжээлшгүй их хүчтэйгээ мэдэх болно.

- Тэд юу хийж чаддаг юм бэ? - гэж Леголас гайхав.

- Би мэдэхгүй – Мэддэг сэн бол доо! Тэд ч өөрсдөө мэдэхгүй байгаа байх – гээд Гэндальф дуугүй болж, тонгойн суув. Найзууд түүнээс нүд салгалгүй харж байв. Нар түүний гарыг гэрэлтүүлж, алга нь амьд төгс гэрлээр гийв. Тэр тэнгэр өөд харлаа:

- Үд дөхөж байна. Хөдөлье.

- Модон болоод хоббитууд байгаа газар руу юу? - гэж Арагорн асуув.

- Үгүй ээ, бид тийшээ явахгүй. Би та нарт найдвар төрүүллээ, гэвч найдвараас ялалт хүртэл тэнгэрийн од хүртэхтэй адил зайтай байдаг юм. Биднийг дайн дуудаж байна. Бидний найзууд бүгдээрээ тулалдаж байна. Энэ дайнд гарцаагүй ялалтыг зөвхөн бөгж л авчрах болно. Гашуудал, түгшүүр хоёр намайг эзэмдэж байна. Учир нь энэ дайнд биднийг агуу их гарз хохирол хүлээж байна. Магадгүй бүх нийтийн мөхөл ч байж болно. Би Цагаан Гэндальф, гэхдээ яг одоо хар хүчин давамгайлж байна.

Тэр босч, зүүн зүг рүү саравчлан хараад толгой сэгсэрлээ.

- Үгүй ээ, - гэж тэр аяархан хэлээд - Тэрнийг одоо буцаах арга байхгүй, ядаж энэнд баярлацгаая. Бөгж одоо бидний хувьд өдрийн бодол, шөнийн зүүд биш болсон. Бид сүүлчийн найдвараа тээж, сүйрлийн өөдөөс явж байна. Гэвч үхлийн аюул өнгөрсөн – гээд эргэн харж: - Эр зоригоо хөвчил, Араторны хүү Арагорн! Дайсны хөндийд чи сонголтоо хийсэн. Сонголтдоо бүү харамс. Хүнд эргэлзээний үед чи хүн мөснийхөө заасан замыг сонгосон. Чи зөв сонголт хийсэн, үр дүн нь ч хурдан ирлээ. Бид цагаа олж уулзлаа. Андууд чинь өөрсдийнхөөрөө шийдэг. Тэд хийдгээ хийчихлээ. Харин чи Теодений өргөө Эдорас руу явах хэрэгтэй, тулаанаар цангасан илд Андрил чинь аянга цахилгаанаас хурц гялалзах болтугай! Ристанид дайн дүрэлзэж байна, гэвч Теодений хүч мөхөс байгаа нь дайнаас ч аюултай.

- Тэгэхлээр бид хөгжилтэй бяцхан хоббитуудаа дахиж хэзээ ч харахгүй болох нь ээ? – гэж Леголас асуув.

- Би тэгж хэлээгүй. Яаж мэдэх билээ! Чи хаана илүү хэрэгтэй байна, тийшээ л яв, тэвчээр заа, итгэл найдвараа бүү алд. Ингээд Эдорас руу урагшаа! Одоохондоо би та нартай зам нийлнэ.

- Явган аянчид хөгшин ч бай, залуу ч бай эндээс Эдорас хүртэл бэдрэх хол байна. Биднийг очих гэсээр байтал дайн болдгоо болоод дуусна - гэж Арагорн хэлэв.

- Харж байж больё - гэж Гэндалф хэлээд: - Тэгээд чи надтай явах юм уу, үгүй юм уу?

- Явнаа, бид бүгдээрээ хамт явна. Гэвч чи хүсвэл надаас түрүүлээд явж болно - гэж Арагорн хариулав.

Тэр босч, Гэндалф руу удаанаар харав. Тэр хоёр өөд өөдөөсөө харалцан дуугүй зогсч, Леголас, Гимли хоёр ч үг дүүгүй ажиглаж байв. Арагорны хүү Арагорн илдэн дээрээ гараа тавин чулуун хөшөө мэт сүрлэг дүртэй зогсоно. Агуу их эзэн хаан тэнгисийн чанадаас эзэнт гүрэндээ эргэж ирсэн мэт санагдав. Түүний өмнө он жилүүдийн нугачаанд бөгтийсөн өвгөн – газар дээрх бүх хаадаас дээгүүр их эрх мэдэлтэй, цав цагаан өмсгөлт их шидтэн зогсоно.

- Чи хүссэн цагтаа хаана л бол хаана надаас түрүүлж ирдэг гэж би үнэнээсээ хэлсэн Гэндалф, дахиад нэг юм хэлье. Чи бол бурхнаас бидэн рүү илгээсэн удирдагч. Хар эзэнд есөн шидтэн бий, гэвч манай удирдагч Цагаан морьтон тэднээс бүгдээс нь хүчтэй. Тэр гал дундуур гарсан, ёроолгүй харанхуй түүнийг залгисан, гэвч аль нь ч түүний өмнө хүчин мөхөсдсөн. Бид түүний араас хаашаа ч байсан дагана – гэж Арагорн хэлэв.

- Бид гурав танаас хоцрохгүй. Ганцхан Морийд юу туулж гарснаа бидэнд ярьж өгөөч Гэндалф, ярихгүй гэж үү? Нэг их удахгүй биз дээ, андуудын чинь зүрх сэтгэл нэг л хөнгөрч өгөхгүй байна! – гэж Леголас хэлэв.

- Бид тэртэй тэргүй удчихаад байна, цаг биднийг хүлээхгүй, тэгээд ч ярья гэвэл нэг жил гаруй хугацаа хэрэгтэй.

- Жил гаруй ярих хэрэггүй ээ, хагас цаг л ярьж болно шүү дээ. Ядаж Барлогийг яаж дийлснээ ярьж болно шүү дээ - гэж Гимли гуйв.

- Тэрний нэрийг бүү дурс! – гэж Гэндалф цочин агзасхийж, нүүр нь үхсэн мэт сааралтан, таг чимээгүй болсноо ихэд хүчлэн санаж байгаа янзтай ярьж эхлэв. Би доошоо маш удаан унасан, тэр надтай хамт унаж, галаараа намайг ясанд хүртэл түлсэн. Дараа нь тэр бид хоёрыг хар ус залгиж, булшны хүйт миний зүрхийг хөлдөөсөн.

- Дарины гүүрний доогуурх харанхуй ёроолгүй, түүнд хэмжээ байхгүй – гэж Гимли амандаа гүвтнэв.

- Тэр ёроолгүй биш, зүгээр л хэмжээлшгүй гүн - гэж Гэндалф хэлээд – гэвч би тэрний ёроолд хүрсэн, тэр ч бас хамт хүрсэн, галаа алдаад тэр аварга могой шиг гулсамхай, хүчирхэг болсон. Газар дорх тэр нүхэнд бид хоёр үргэлжлүүлэн тулалдсан. Тэр намайг могой шиг ороон дарахад нь би илдээрээ хүү татсан, тэгээд л тэр нэг нарийхан муруй тахир хонгилоор зугтаасан. Тэр хонгилыг Дарины ардууд зээтүүгээрээ ухаж гаргаагүй юм, Глоины хүү Гимли минь. Тийм гүнд нэг ч гном орж үзээгүй. Уулын доогуурх чулуун агуйнуудыг Саурон ч мэдэхгүй хачин амьтад эзэгнэсэн байна лээ. Тэр амьтад түүнээс ч эртний юм чинь яаж мэдэх билээ. Би газар дээрх гэрлийг бүдэгрүүлэхгүйн тулд тэндхийн аймшигт харанхуйн талаар юу ч хэлэхгүй. Би тэндээс зөвхөн дайснаа дагаж л гарч чадах байсан учир би араас нь салалгүй хөөсөн. Аргагүйн эрхэнд тэр намайг Казад-Думын нууц гарцанд хүргэсэн. Тэр гарцаар бид хоёр төгсгөлгүй шатанд хүрсэн.

- Тэр шатны тухай ч мартсан даа, зарим нь тэрнийг үлгэр гэдэг юм, зарим нь аль дивангарт нурсан гэдэг юм. Тэр шат олон мянган гишгүүртэй, газар доороос Дарины цамхаг хүртэл мушгиралдаж өгсдөг, тэр цамхаг Зиракзигил буюу Мөнгөн эвэр, эльфээр Келебдор гэдэг шовх оройт хясаан дээр байдаг юм. Тэнд мөс цоолж гаргасан ганцхан цонхны цаана бүргэдийн үүр шиг нэг өндөрлөг байдаг юм. Дээр нь нар гялалзаж, доор нь үүл хөвсийж байдаг юм – гэж Гимли үг нэмэрлэв.

- Би тэрний араас гараад иртэл тэрний толгой галаар тургисан. Оргилуудын оргил дээрх тэр тулалдааныг хэн ч хараагүй, харсан бол тэр тулааны тухай үеийн үед дуулагдах дуу зохиогдох байсан биз – гээд Гэндалф гэнэт инээж: - Гэвч юу гэж зохиох вэ дээ, Келебдорын орой дээр тасралтгүй аянга нижигнэн цахилгаан цахилж, бөөн бөөн гал тасарч байсан гэж алсаас харсан хүмүүс ярьсан байна лээ. Дуу зохиоход энэ ч хангалттай юм болов уу? Бид хоёрын дээгүүр утаа бүрхэж, мөс ууршин бөөн бөөнөөр хагарч байлаа. Би дайснаа дийлсэн. Тэр үүлний дээрх оргил дээрээс унаж, уулсын хад хясааг нурааж байлаа. Гэвч намайг харанхуй бүрхэж, би орон зайгүй, цаг хугацаагүйд төөрсөн.

Хугацаа дуусахын даваан дээр Нагим намайг энэ ертөнцөд буцаасан, тэгээд л би уулын оргил дээр ухаан орсон юм. Цонх ч байхгүй, цамхаг ч байхгүй болсон байлаа. Шатыг шатсан чулуунууд овоорон хаасан байв. Би хаанаас ч, хэнээс ч тусламж ирнэ гэж найдалгүй дэлхийн дээвэр дээр цор ганцаараа хэвтэж байв. Миний дээгүүр одод яралзаж, өдөр хоног надад эрин зуун шиг урт байсан. Би газар дээрх амьдралын бүдэг чимээ, амь тавин хашгирах, төрж буй хүүхдийн уйлаан, найрын дуу, оршуулгын орилоон, ядарсан газрын удаан хүнд ёолооныг мэдэрч байсан. Тэгтэл Гвагир Салхин жигүүр нисэн ирж, намайг аваад хаа нэг тийш ниссэн.

“Намайг гай зовлонд учрахад дандаа авардаг чи миний жинхэнэ найз, би чиний мөнхийн ачаа юм даа” – гэж би түүнд хэлэхэд:

“Чи надад ачаа болж байсан цаг бий, гэхдээ одоо бол тийм биш. Би сарвуундаа хунгийн өд атгаж явна. Нарны гэрэл чамайг нэвт ээж байна. Дахиад би чамд хэрэггүй. Буулгалаа - Чи тэгээд салхитай хамт хөв” гэж тэр хэлэв.

“Хэрэггүй, битгий буулга! Намайг Кветлориэнд хүргэж өг!” – гэж би бага зэрэг ухаан сэргээд хэлэхэд.

“Хатан хаан Галадриэль намайг чам руу илгээхдээ ингэж л хэлсэн дээ” – гэлээ.

Тэгээд л тэр намайг Галадхэнд хүргэж, та нар тэндээс дөнгөж хөвсний дараахан шүү дээ. Юу хөгшрүүлж, юу эдгэрүүлдгийг та нар мэднэ. Тэгээд л би бүрэн бүтэн болж, эдгэрсэн. Надад цагаан хувцас өмсгөж, би зөвлөх болсон. Би тэндээс ер бусын замаар ирсэн, тэндээс та нарт хатан хааны аман илгээлтийг авчирсан. Арагорнд ингэж хэлсэн:

Алс Умардыг гийгүүлэн гялалз,

Эльфийн гэрэлт эрдэнэ минь!

Анд нөхдөө зэвсгээ барихыг уриал,

Элгэн саднаа цуглуул.

Агуу дүрийг чинь тэд харна, уриаг чинь сонсоно.

Амьд бүхэн нь чамд хариу өгнө.

Саарал бүлэг өмнө хязгаар руу хөдөлнө.

Санаанд багтамгүй их ачааг чи ганцаар үүрнэ:

Тэнгист хүрэх шууд замыг чинь үхдлүүд засна.

Харин Леголас чамд Галадриэль ингэж хэлүүлсэн:

Бөглүүд ойн хаан минь!

Ойн сэрүүнд амар жаргаж асан билээ

Одоо чи амар тайвнаа алдсан! -

Эрэмгий цахлай шувуудын дуудлага,

Эргийн давалгааны нижигнэх чимээ

Ойн нам гүмээс ч илүү

Онцгой жаргалыг чамд бэлэглэнэ.

Гэндальф дуугүй болж, нүдээ анив.

- Надад юу ч хэлүүлээгүй юм биз дээ? - гэж Гимли асуугаад толгой унжуулав.

- Түүний үг учир битүүлэг байна. Миний ухаан утгыг нь тайлж хүрэхгүй нь - гэж Леголас хэлэв.

- Энэ чинь намайг тайвшруулахгүй – гэж Гимли бувтнав.

- Чамд бүгдээс илүү юм хэрэгтэй юм уу? Тэр чиний үхлийг урьдчилж хэлэхийг хүсээ юу?

- Хэрэв надад хэлэх үг байхгүй бол тэгсэн нь дээр.

- Та хоёр юун тухай яриад байна? – гэж Гэндальф асуугаад: - Та нарт илгээсэн үгс миний ухаанаар бол тодорхой юм хэлж байна шүү. Өршөөгөөрэй, Гимли! Би сая түрүүчийн хоёр илгээлтийн утгыг бодсон юм. Бас бүрхэг ч биш, гунигтай ч биш гурав дахь илгээлт бий шүү:

- “Глоины хүү Гимлид түүний хатан мэхийн ёсолж байна. Миний сэтгэл чиний араас салшгүй дагаж байгаа, миний туг үсийг хадгалагч минь. Чиний эр зориг бүү хөрөг, чиний сүх зөвхөн цавчих ёстой юмыг л цавчиг!” – гэж тэр хэлүүлсэн дээ.

- Чи ёстой цагаа олж бидэндээ эргэж ирлээ дээ, Гэндальф! – гэж Гимли хашгирах шахам дуу алдсанаа босон харайж, гном хэлээрээ зэрлэгдүү дуу аялан бүжиглэж гарав. Тэр сүхээ толгой дээгүүрээ эргүүлэн:

- За одоо дайснууд минь, тэсээрэй дээ! Гэндальфыг буруу угтсан нь үнэн. Харин одоо цавчих ёстой толгойнуудыг сайхан цавчина даа! – хэмээн хашгирав.

- Удаан хүлээхгүй Гимли минь - гээд Гэндальф босч:

- За сайхан ярилцлаа, эхний удаад ингээд болно, замдаа гарцгаая!

Тэр дахиад л саарал тамтагнуудаа углаад, түрүүлэн алхлаа. Тэд уулнаас чимээгүй, хурдан буугаад Онтава хүрч, эрэг даган ойн захад гарч, аварга царс модны дэргэд очлоо. Морьдын бараа сураг ч алга.

- Морьд ирсэнгүй, алхаад л байхаас - гэж Леголас хэлэв.

- Надад явган алхах зав алга - гээд Гэндальф бусдыгаа эргэж хартал нь тасхийтэл айхтар чанга шүгэлдэв. Энэ их сахалт дөлгөөн сайхан өвгөн ингэж чанга шүгэлдэнэ гэж үү? – хэмээн найзууд гайхав. Тэр гурвантаа шүгэлдэхэд алсаас морьд янцгаалдах нь сонсогдож, гурван найз гайхан чагнав. Арагорн хэвтэж, чихээ газарт наагаад улам ойртсоор байгаа морьдын төвөргөөнийг сонслоо.

- Нэг морь биш л байна даа - гэж Арагорн хэлэхэд:

- Мэдээж ганц биш, дөрвөн хүнд нэг морь цөөднө - гэж Гэндальф хариулав.

- Гурван морь байна! – гэж Леголас талын тэртээ рүү ширтэн хэлээд - Мөн ч сайхан давхиж байна даа! Энэ Хазуфел байна, миний Арод мөн байна! Гурав дахь нь түрүүлж явна. Би ийм том морь амьдралдаа ч үзээгүй юм байна.

- Үзэх ч үгүй, энэ бол Аянга – Бэмаруудын хаан сүргийн тэргүүн, ийм морь Теоденд хүртэл ахадна. Мөнгөлөг өнгөөр гялалзаж, гол горхи шиг жигд хэмнэлтэй харайж байгааг нь харж байгаа биз дээ! Болох тулалдаануудад миний дайчин анд Цагаан морьтод яг тохирно – гэж Гэндальф хэлэв.

Өвгөн шидтэнг ийнхүү ярьж байхад саглагар дэлтэй сайхан цагаан морь мөнгөлөг гэрэл цацруулсаар алсаас давхин гарч ирэв. Хазуфел, Арод хоёр арай хоцорсхийж, Аянга хөнгөхөн хатиран ирээд зогсч, бардам тэргүүнээ өвгөний мөрөн дээр тавилаа. Гэндальф түүний хөхөлийг энхрийлэн илж зогсоно.

- Уудам хөндийгөөс давхиж ирэхэд хол боловч чи минь яг цагтаа ирлээ. Одоо хамтдаа давхия, эцсийн өдрөө хүртэл дахиад салахгүй биз дээ! Бид танай эзэн захирагчийн өргөө Медусельд рүү яарч байна – гээд Гэндальф хүлээх мэт зайдуухан зогсч байгаа хоёр моринд хандаж:

- Цаг давчуу байна. Найзууд минь, хурдаа шалгахыг би та нараас гуйж байна шүү. Хазуфелын эзэн Арагорн, Ародын эзэн Леголас. Гимлиг би дүүрнэ. Аянгад хүнддэхгүй гэж найдаж

байна. Онтавын уснаас ханатлаа уучихаад шууд хөдөлнө - хоёр морь ойлгосноо илэрхийлэн толгой дохив.

- Одоо би урьд шөнө юу болсныг ойлгож байна. Эхлээд тэд айсан байж магадгүй, дараа нь өөрсдийнхөө тэргүүн Аянгын өөдөөс баярлан янцгаасаар давхижээ. Тэр холгүй байсан гэдгийг чи мэдэж байсан уу? – гээд Арагорн мориндоо үсрэн мордов.

- Мэдэж байсан, өчигдөр морь минь өмнө зүгт их хол байсан болохоор би түүн рүү сэтгэлийн хүчээ чиглүүлж, яарахыг хүссэн юм. Ингээд л мөнгөн сум шиг нисээд ирлээ!

Гэндальф бөхийж, Аянгын чихэнд нэг юм хэлэхэд Аянга хоёр найз руугаа эргэн хараад ухасхийн Онтава руу давхив. Хоромхон зуурт тэр голын гарам дээр хүрлээ.

Аянга нэг захаасаа нөгөө захаа хүртэл саарал өвс давалгаалсан замгүй талаар өмнө зүг давхилаа. Ямар ч зөрөг, жим байхгүй атал Аянга газраас хөндий нисч байгаа юм шиг хурдална.

- Шууд Эдорас руу, Цагаан уулын бэл хүртэл давхих гэж байна, тэгвэл зам дөтлөх болно. Аянга замгүй газраар ч хаагуур явахаа мэднэ – гэж Гэндальф тайлбарлалаа. Өндөр өвс морьтнуудын өвдөг шүргэж, морьд ногоон саарал тэнгист хөвж яваа юм шиг санагдаж байлаа. Аянга зам гаргаж, нөгөө хоёр нь түүний мөрийг алдалгүй дагана.

Нар хязгааргүй талын хаяа руу баруун тийш ташиж, өвсний өнгө хүрэнтэж эхлэв.

- Энэ бол Ристаниин хаалга, биднээс шууд баруун талд байна, арай хойшоо, тээр цаана Изенгард байгаа - гэж Гэндальф тайлбарлав.

- Утаа үүлийг бүрхэж байна, тэнд юу болоод байна, түймэр юм болов уу? - гэж Леголас хэлэв.

- Их тулаан болж байгаа юм! Урагшаа ! – гэж Гэндальф хэллээ.

Бүлэг 6

Алтан өргөөт эзэн захирагч

Тэнгэрийн хаяаны үүлсийг хормойноос нь асаах мэт час улаан туяа татуулан наран жаргаж, хэсэгхэн зуурт бүрэнхий болсноо шөнийн харанхуй шууд залгав. Тэд морины хурдаар давхисаар эцэст нь морьдоо түр амраахаар жолоо татахад хэтэрхий яаран мориныхоо дэлд наалдах шахам бөхийж явсандаа Арагорн хүртэл тонгорцоглон унах дөхөв. Гэндальф хэсэгхэн зуур унтаж амар гэж захирахад Леголас, Гимли хоёр газарт толгой хүргэнгүүт хурхирч, Арагорн хоёр гараа алдлаад, тэнгэр өөд ширтэн хэвтэв. Өвгөн шидтэн таягаа тулан, харанхуйг нэвт харах мэт өрнө, дорно зүг рүү ширтэн зогсоно. Шөнийн нам гүмд өвс сэрчигнэнэ. Тэнгэр эцэс төгсгөлгүй нүүж байгаа үүлэнд бүрхэгдэн, хааяа нэг бүдэгхэн сарыг нүцэглэж авай. Дахиад л замаа хөөж, морьд сарны бүдэгхэн гэрэлд өдрийнх шигээ сурмаг хурдлав.

Дахиад нэг ч удаа жолоо татсангүй. Гимли будаа тонших тагтаа мэт тонголзох бөгөөд Гэндальф тэвэрч яваагүй бол аль хэдийн Аяндын нуруун дээрээс түүдэг ноос мэт хийсэх байлаа. Хазуфел, Арод хоёр Аянгад тэлэгдэж ядарсан ч, молор эрдэнийн толгойгоо бардам өргөн, өмнө нь дөнгөн данган үзэгдэх саарал сүүдэр болон нисэх сүргийн тэргүүнийхээ араас чардайтал харайж байлаа. Алсын зам архан талд бээр бээрээр сунайн хоцорч, цонхигор саран үүлэн хөшигний цаагуур нуугдав.

Жихүүн өглөө боллоо. Дорно зүгт манан сийрэгжин сааралтав. Зүүн талаас Дайсны уулсын хар оргилуудын дээгүүр улаан туяа цацарлаа. Тал нутгийг хурц тодхон үүрийн туяа гийгүүлж, салхи түүний замд тээглэх шиг, хүйтэнд бээрэн бөхийсөн өвсөн далайг сэгсчин сэрээж байвай. Аянга гэнэт шаасан гадас мэт зогтусан хангинатал янцгаав. Гэндальф гар сунган урагш заалаа:

- Харцгаа! – гэж тэр тасхийтэл хэлэхэд дагуулууд нь нойрмог нүдээ өргөв. Тэдний өмнө атираатсан гүн жалганууд бүхий эгц оройт цасан цагаан оргилууд дүнхийж үзэгдэв. Түүнээс доош намхан уулс ногоорон, уул талын уулзвар олон хөндий үүрийн гэгээнд хараахан тод харагдахгүй ч, хамгийн том, урт хөндий нь нүдний өмнө илхэн цэлийж харагдав. Тэр хөндий цасан оройт уулсад хүрч байлаа.

- За Леголас! Юу харж байгаагаа бидэнд хэлээд орхи!- гэж Гэндальф захирав.

Леголас мандаж буй нарнаас нүдээ алгаараа халхлаад:

- Хөндийн зүүн захын ногоон уулын бэлээс гарч ирж байгаа гол цаст оргилоос бууж, гүн жалга руу орж байгааг би харж байна. Уул өндөр хана, шовх үзүүртэй хэрмээр хүрээлэгдсэн байна. Уулын хажуугаар байшингуудын дээвэр цухуйж байна, цайзын голд өндөр орд өргөөтэй өндөр цамхаг байна. Өргөө нь алтаар бүрсэн юм шиг байна, маш тодоор туяарч байна. Хаалганы баганууд нь ч алтаар өнгөлсөн байна. Хаалганы дэргэд гялалзсан хуяг дуулгатай харуулууд зогсч байна. Цайзад ямар ч хөл хөдөлгөөн алга, бодвол бүгдээрээ унтаж байгаа бололтой.

- Энэ цайзыг Эдорас гэдэг юм. Алтан өргөөг Медусельд гэдэг. Энэ ол Мустангримын эзэн захирагч, Тэнгэлийн хүү Теодений нийслэл. Бид үүрээс өмнө ирсэн нь сайн хэрэг. Бидний зам энэ байна. Болгоомжтой явах хэрэгтэй, дайны цаг, Ристанийн морьт дайчид унтах байтугай зүүрмэглэдэг ч үгүй, холоос бид ямар ч харагдаж болно. Зэвсгээ шүүрч болохгүй, хэлээ зоргоор нь тавьж болохгүй, үүнийг би та нарт бүгдэд нь хэлж байна, өөртөө ч сануулж байна. Биднийг Теоден рүү эв зүйгээр оруулах нь чухал – гэж Гэндальф ярилаа.

Цэлмэг тунгалаг өглөө болж, тэднийг гол руу орж ирэхэд эртэч шувууд шуугилдан жиргэж байлаа. Гол сүр чимээ ихтэй мушгиралдан урсч, тэдний зам өргөн гармаар хөндөлсөн, зүүн зүг рүү тэмүүлсээр Онтавагийн зэгст салаанууд руу оджээ. Өтгөн ургамлалт эрэг нь бургасаар бүрхэгдэж, аль хэдийн өмнөд газрын өтгөн хүрэн өнгөөр гөлөглөж харагдана. Өргөн бөгөөд гүехэн гарам морин туурайд давтагджээ.

Аянчид голоор гараад уулын бэл дэх өндөр хиргисүүрүүдийн хажуугаар цайз руу хөтөлсөн өргөн замаар оров. Уулын баруун талын ногоон хажууг одон цэцэг цас мэт хучжээ.

- Хараач, ямар хурц гэрэлтэж байгааг нь! Дурсамж цэцэг гэдэг юм, эндхийн хэлээр бол симбельмейн буюу булшны цэцэг, дөрвөн улирлын турш цэцэглэдэг. Энэ бол Теодений өвөг дээдсийнхний булш байгаа юм – гэж Гэндальф ярилаа.

- Зүүн талаасаа долоон хиргисүүр, баруун талаасаа ес – гэж Арагорн тоолоод. – Алтан өргөө сүндэрлэснээс хойш олон амьдрал урсаж дээ – гэлээ.

- Манай Бөглүүд ойд энэ хугацаанд улаан навч таван зуун удаа хагдарсан байна, гэвч манайхаар бол энэ хугацаа биш л дээ – гэж Леголас хэлэв.

- Танайхаар бол тийм, харин мустангримчүүдэд цаг хугацааны өөр тоолол байдаг юм. Өргөөг яаж барьсан тухай зөвхөн дуунд л өгүүлдэг, түүнээс өмнө юу байсныг хэн ч санадаггүй. Энэ хязгаарыг эд нар өөрийнхөө газар нутаг гэдэг, эдний хэл яриа умардын садан төрлүүддээ ч ойлгогдохоо больсон – гэж Арагорн хэлээд эльфэд ч, гномд ч ойлгомжгүй хэлээр удаан аятай нэг дуу аяархан аялсанд уянгат урт ая нь бүгдэд таалагдав.

- Сонсохоор Ристанийн аялга энэ нутаг шигээ, уул тал шигээ нэг уянгалаг чөлөөтэй, нэг хатуу, огцом байх юм. Гэхдээ би юу ч ойлгоогүй. Баатарлаг үхлийн тухай гуниг мэдрэгдээд байна – гэж Леголас хэлэв.

- Нийтийн хэлээр бол нэг иймэрхүү маягаар орчуулж болно – гэж Арагорн өгүүлэв:

Эрэмгий хөлөг нь хаа байна,

Эрэлхэг дайчин нь хаачив?

Эвэр бүрээ нь хаа байна?

Хуяг дуулга нь хаа байна,

Хурц илд нь хаа байна?

Бардам дур нь хаачив?

Баясгалант хөгжим нь хаа байна,

Бадарсан түүдэг нь хаа байна?

Өнгөлөг хавар, ногоон зун, алтан намар хаачив?

Өнгөрсөн өдрүүд уулын аадар, талын салхинд туугдан

Өвгөрсөн уулсын цаагуур өнө мөнхөд алга болов.

Уй гашуу утаа болон замхарч,

Урам зориг галаар дүрэлзэн айсуй.

Аль дивангарт мартагдсан Ристанийн нэг дууч баатар вангуудын тэргүүн Анхдагч Эорлд зориулж энэ дууг зохиосон юм. Тэр агуу баатар ван умар зүгээс энд давхиж ирэхэд өнөөгийн Мустангримын адуун сүргийн элэнц эцэг – Феларофын туурайнаас жигүүр ургасан гэдэг юм. Өнөө ч гэсэн мустангримчүүд түүдэг галын дэргэд энэ дууг дуулдаг юм.

Нам гүм хиргисүүрүүдийг ороосон зам ногоон хажуу өөд өгссөөр олон оны салхинд элэгдсэн бат бэх цайзын хана даган хөтөлж Эдорасын хаалганд авчирлаа.

Хаалганы хоёр талд сууж байсан арав гаруй харуул нэгэн зэрэг босон харайж, жаднуудаа зөрүүлэн зам хаав.

- Бүү хөдөл, үзэгдээгүй харийнхан минь! – гэж тэд ристани хэлээрээ тушаагаад, эхлээд нэрээ, дараа нь хэрэг зорилгоо хэлэхийг шаардав. Тэдний харц ихэд гайхсан шинжтэй, найрсаг нөхөрсөг шинж огтхон ч үгүй, Гэндальф руу дайсагнасан байдалтай харах ажээ.

- Танай хэлийг ойлгож байгаа минь сайн хэрэг, гэхдээ хэрэн бэдрэгч бидэн заавал танай хэлийг мэдэх албагүй, яагаад та нар өрнөд газрын ёсоор нийтийн хэлээр бидэнд хандахгүй байна вэ? – гэж Гэндальф асуув.

- Эзэн захирагч Теоден гагцхүү манай хэлийг мэддэг, бидэнтэй найрамдалт харилцаатай хүмүүсийг л оруул гэж тушаасан юм. Дайны өдрүүдэд бидэн дээр мустангримчүүд, гондорчууд, Мундбургийн элч нараас өөр хэн ч ирэх ёсгүй. Манай тал нутгаар ер бусын хачин хувцастай мөртөө манай морьдтой усны дусал шиг адилхан морьд унаад хэсч явдаг та нар хэн юм бэ? Бид шөнөжин харуулд зогссон учир та нарыг их холоос харсан. Амьдралдаа бид та нараас хачин ардуудыг үзээгүй, хоёр хүн сундалдсан энэ мориноос сайхан морь хараагүй. Энэ морь Бэмарын сүргийнх байна, эсвэл бидний нүдийг ховсдож орхисон байх. Чи босоо ороолон уу, Саруманы тагнуул уу, эсвэл шидийн хий үзэгдэл үү? Хэл, нэн даруй хариул! - гэж харуулуудын ахлагч зандрав.

- Бид сүг сүүдэр, буг чөтгөр биш, өөрийнхөө нүдэнд итгэж болно - гэж Гэндальфын өмнөөс Арагорн хариулаад - Бидний морьд танайх гэдгийг мэдэж байгаа бол асуугаад байх юм алга.

Морины хулгайч хулгайлсан морио эзэнд нь авчирч өгдөггүй юм. Энэ бол Хазуфел, энэ Арод. Мустангримын гуравдугаар жанжин Эомер бидэнд энэ хоёр морийг зээлдүүлсэн юм. Эомер эргэж ирээгүй, та нарт бидний тухай анхааруулаагүй юм уу?

Харуулын ахлагч харваас илт сандарч байв.

- Эомерийн тухай бид ярихгүй, - хэмээн тэр харцаа бултуулж - Харин та нар үнэн хэлж байгаа бол эзэн захирагчид илтгэх хэрэгтэй. Та нарыг хүлээж байгаа биз дээ. Хоёр хоногийн өмнө Өмхий Амт бидэн дээр бууж ирээд, Теодений нэрийн өмнөөс нэг ч харийн хүн оруулж болохгүй гэж тушаасан юм.

- Өмхий Амт гэв үү? - хэмээн Гэндальф харуулыг ширүүн харцаар шилдбүүрдээд: - Тэгвэл нэг ч үг бүү дуугар! Өмхий Амттай уулзах хэрэг надад байхгүй, би Мустангримын эзэн захирагчтай уулзах хэрэгтэй. Тэгэхдээ маш яаралтай. Чи өөрөө явах юм уу, нэгийгээ явуулах юм уу, биднийг ирсэн гэж илтгэ.

Гэндальфын нүд саглагар хөмсгөн дороосоо гялалзаж, хөмсөг зангидав.

- Би явлаа - гэж харуул баргар царайлаад - Гэвч хэн ирсэн гэж илтгэх юм бэ? Чиний тухай яаж хэлэх юм бэ, харахад өтөл дорой өвгөн байна, гэтэл аймшигтай их хүчтэй чинь мэдрэгдэж байна.

- Чи үнэн харсан байна, зөв ч ярьж байна – гэж шидтэн хэлээд: Би

Гэндальф. Би эргээд ирлээ, чамайг харсаар байтал хэний ч гарт үл орох Мөнгөн Аянгыг унаад ирлээ, миний дэргэд танай эртний хаадын удам Араторны хүү Арагорн зогсч байна, тэр Мундбург орох гэж яваа. Харин энэ хоёр бол бидний шалгарсан андууд, эльф Леголас, гном Гимли хоёр. Хурдан эзэндээ очоод бид хаалган дээр хүлээж байна, өргөөндөө оруулбал ярих юм байна гэж хэл.

- Гайхамшиг гэхээс өөр юу гэхэв дээ! – хэмээн харуул мөрөө хавчаад: - Чинийхээр больё, би эзэн захирагчид илтгэе, тэр өөрөө яахаа мэдэг. Жаахан хүлээж байгаарай, би одоохон хариу аваад ирнэ. Гэхдээ битгий их найдаарай, одоо чинь их цөвүүн цаг шүү дээ.

Тэгээд харуулын ахлагч харийнхныг бусаддаа даатгаад хурдан алхлан одов. Тэр үнэхээр хурдан эргэж ирлээ.

- Намайг дагаад яваарай! Теоден та нарыг өргөөндөө урьж байна, харин бүх зэвсгээ, таягаа ч хаалган дээр орхих болно. Харуулууд найдвартай хамгаална.

Найрсаг бус хаалга нээгдэж, аянчид харуулын ахлагчийн араас нэг нэгээрээ цувран оров. Чулуун хавтан тавьсан гудамж уул өөд мурилзан өгсчээ. Тэд дүнзэн байшингууд, дүнсгэр хашаанууд, хаалттай хаалгануудын хажуугаар өгсөн, чулуун эрэгтэй элбэг уст горхинд хүрэв. Уулан дээр гараад ногоон дэвсэг дээр чулуун агуй, агуй дотроос адууны том баримал цухуйж, түүний амнаас асар том хуланд тунгалаг ус олгойдож, тэндээс горхи эх авсан байхыг харав. Удам өргөн, урт гантиг шат алтан өргөөний хаалга хүрч, хоёр талаар нь эзэн захирагчийн

хамгаалагчдын чулуун суудлууд эгнэжээ. Хамгаалагчид өвдгөн дээрээ нүцгэн илдээ тавин сууцгаана. Туузаар боосон алтлаг үс нь мөрөн дээрээ намиран бууж, наран сүлдийг нь ногоон бамбай чимэглэн, хөө хуягны толь нь гялалзан гэрэлтэнэ. Хамгаалагчид нэгэн зэрэг дэрхийн босоход ердийн хүнээс бүтэн толгой өндөр байв.

- Та нар тийшээ ор, би хаалга руугаа буцлаа, баяртай, Мустангримын эзэн захирагч та нарт өгөөмөр элэгсэг хандах болтугай!- гэж харуулын ахлагч хэлэв.

Тэр үүрч явсан ачаагаа буулгасан мэт хөнгөхөн алхалсаар буцлаа. Аянчид өндөр ханхар хамгаалагчдын хажуугаар урт шатаар өгсөв. Тэд дээд талын тавцан дээр зогсоход Гэндальф гүүрүүлж алаг хуарт шалан дээр гишгэлээ. Тэр даруйд ристани хэлээр найрсаг мэндчилэх сонсдов:

- Амгалан морилогтун, алсын зочид минь! – хэмээн хамгаалагчид мэндлээд илднийхээ бариулыг урагш харуулахад ногоолин эрдэнэс гялалзав. Дараа нь хамгаалагчдын нэг нь урагш нэг алхаад нийтийн хэлээр:

- Би Теодений ахлах хамгаалагч Гайма байна, бүх зэвсгээ энэ ханын дэргэд орхихыг хүсч байна - гэлээ.

Леголас түүнд мөнгөн чимэгт кинжаал, нум саадгаа өгөв.

- Миний зэвсгийг нандигнаарай, Алтан ойн хатан хаан надад бэлэглэсэн юм – гэж тэр хэлэв.

Гайма гайхан нүдээ мэлтийлгэснээ зэвсгийг ихэд эмээсэн байртай ханын дэргэдэх ширээн дээр эвтэйхэн тавилаа.

- Та тайван бай, хэн ч гар хүргэхгүй – гэж тэр хэлэв.

Арагорн эргэлзэж:

- Би Андрилыг өөр хүнд найдан орхиж чадахгүй нь ээ – гэхэд Гайма:

- Теодений зарлиг шүү дээ.

- Тэнгэлийн хүү Теоден Мустангримын эзэн захирагч боловч Гондорын хууль ёсны эзэн хаан Элендилийн удам Араторны хүү Арагорнд зарлиг биш.

- Энэ өргөөний эзэн Теоден болохоос Арагорн биш, Гондорын хаан ширээнд Денэторын оронд суусан байлаа ч энэ өргөөний эзэн Теоден – гээд Гайма тэдний замыг хаахад илд нь ирээрээ эргэсэн байлаа.

- Дэмий яриа - гэж Гэндальф хэлээд: - Теодений зарлиг ухаалаг биш байна, гэвч энд маргаад байх юм алга. Эзэн захирагч өөрийнхөө өргөөнд өөрийнхөө тэнэг зарлигийг чөлөөтэй гаргаж болно.

- Үнэхээр тийм – гэж Арагорн зөвшөөрөөд: - хэрэв миний илд Андрил биш байсан бол би

мод огтлогчийн овоохой байсан ч гэрийн эзний хүсэлд захирагдах сан.

- Чиний илд ямар ч нэртэй байсан чи энд тавих ёстой, эсвэл Эдорасын. Бүх дайчидтай ганцаараа тулалдах болно – гэж Гайма хэлэв.

- Яагаад ганцаараа гэж? - хэмээн Гимли асуугаад сүхнийхээ ирийг хуруугаараа илж үзсэнээ цэл залуу мод цавчих гэж байгаа юм шиг эзэн захирагчийн хамгаалагчид руу хайрлаж харамссан байртай хараад: - ганцаараа биш!

- Тайван бай! – гэж Гэндальф захираад: - Бид та нарын анд нөхөд, хамтран тэмцэгчид, бид өөр хоорондоо өчүүхэн маргалдвал Мордорт л ашигтай, тэр баярласан хэрээ бархирна гэдэг болно. Цаг үнэтэй байна. Миний илдийг ав, эрхэм Гайма. Үүнийг ч гэсэн нандигнаарай, нэрийг нь Яррист гэдэг юм, олон мянган жилийн өмнө эльфүүд давтсан юм. Одоо намайг оруулна биз дээ. Харин Арагорн, чи ухаалаг бай!

Арагорн бүсээ удаанаар тайлаад илдээ өөрөө ширээн дээр тавилаа.

- Энд би тавилаа, битгий гар хүргээрэй гэж чамд тушаая. Энэ эльф хуй эртний домогт хугарсан илдийг дахин давтсан шинэ илдийг хадгалж байгаа юм. Анх үүнийг аль дивангарт Тельчар давтсан юм. Элендилийн илдийг шууд залгамжлагчаас өөр хэн ч барьж болохгүй, хүрэх л юм бол тэр дороо амь алдана.

Хамгаалагч арагшаа ухарч Арагорн руу гайхан харав.

- Та аль эрт мартагдсан эрин цагаас дууны дуудлагаар ирсэн юм шиг санагдаж байна, ноён таны хэлсэн ёсоор биелүүлнэ.

- За, тэгвэл ч яахав, - гэж Гимли санаа амарсан байртай хэлээд: - Андрилын дэргэд миний муу сүх жаахан амарч аваг – гээд сүхээ алаг чулуун шалан дээр ханхийтэл тавьж: - Одоо чиний хэлсэн бүхнийг гүйцэтгэлээ, эзэн захирагч руугаа биднийг оруул – гэхэд хамгаалагч:

- Таяг чинь үлдлээ, намайг өршөөгөөрэй, гэвч энийг ч бас хаалган дээр үлдээх ёстой - гэж Гэндальфт хэлэв.

- Ёстой үгүй шүү! – сэрэмжтэй байх гэдэг нэг хэрэг, хэт сэрэмжтэй байсан ч болно, харин бодлогогүй байна гэдэг өөр хэрэг. Би хөгшин хүн. Чи намайг оруулахгүй юм бол Теоден өөрөө над руу ирэх хүртэл би энд сууж байя.

Арагорн инээв:

- Өвгөн юу ч болж байсан таягнаасаа салахгүй нь ээ- гэснээ Гайма руу зэмлэх аятай хараад: Чи үнэхээр өвгөний таягийг үлдээх гээд байна уу? Ингэхгүйгээр оруулахгүй юм уу?

- Шидтэний гарт байгаа таяг тулгуур биш, очир болж мэднэ - хэмээн Гайма Гэндальфын нарсан таяг руу анхааралтай ширтэж хэлээд: - Гэвч эргэлзэх цагт дотоод ухаанаа сонс гэж мэргэд сургасан. Та нар бидний найз нөхөд, та нар шиг хүмүүс муу муухай үйл хийхгүй гэдэгт итгэж байна. Тавтай морилцгооно уу!

Хаалганы нүсэр хүнд түгжээнүүд түржигнэн дуугарч, давтамал гинжнүүд жингэнэлдэж, аварга том хаалга алгуурхан нээгдэв. Уулын цэвэр агаараар сэнгэнэтэл амьсгалж байсан тэдэнд дулаахан, бараг бүгчим гэхээр агаар үнэртэв. Олон баганат өргөөнд бараг харанхуй, зөвхөн зүүн талын өндөр цонхнуудаар нарны гэрэл орж байлаа. Таазан дээрх тонолжин нүхээр утаа гарч, цайвар цэнхэр тэнгэр харагдана. Тэдний нүд өргөөн дотор дасч, чулуун шалан дээрх рун хээг харав. Сийлмэл багануудаас алтны бүдэгхэн туяа ойж, хана туурганд үлгэр домгийн үйл явдлуудыг дүрсэлсэн баримлууд эгнэжээ. Гэтэл олон хивснүүдийн нэгэн дээр гэнэт гэрэл цацарч, цагаан морьтой хөвгүүн том эвэр бүрээ үлээн, алтан шаргал үс нь салхинд үелзэн хийсч харагдав. Морь нь их тулааныг зөгнөн толгойгоо өргөн янцгааж, дун бүрээ хамрынх нь самсаа улайрч харагдлаа. Морины өвдөгт тулсан голын догшин урсгал ногоовтор хөөс буриглуулж байлаа.

- За, Эорлын удам гэдэг чинь энэ дээ! – гэж Арагорн хэлээд: - Тэр умар зүгээс давхиж ирээд Келебрантын тулаанд уулгалан орохдоо ийм л байсан юм - гэв.

Өргөөний голд аварга том тулганаас гал бадарч байна. Тулганы цаана, гурван үе гишгүүртэй алтадмал ширээ байна. Хаан ширээнд гном шиг өвгөн бөгцийн сууж байв. Том гэгчийн очир эрдэнийн чулуутай алтан титэм дороос өтгөн буурал үс нь задарчээ. Цасан цагаан сахал нь өвдөг дээрээ тунаж, урилгагүй зочдын өөдөөс гялалзсан хурц нүдээр ширтэнэ. Түүний ард цагаан өмсгөлтэй залуу бүсгүй зогсох агаад өвгөний хөлийн дэргэд гонзгой толгойтой, үхдэл царайтай, хатаж гүйцсэн хүнэрхүү юм суужээ.

Алтан титэмт өвгөн зочид руу үг дуугүй, хөдлөх ч үгүй ширтэнэ. Гэндальф нам гүмийг эвдэж:

- Сайн байна уу, Тэнгэлийн хүү Теоден! Би дахиад л чам руу ирлээ, их шуурга ойртож байна, энэ бэрх цагт анд нөхөд бүгдээрээ нэгдэж, ганц нэгээрээ хүйс тэмтрэгдэхээс сэргийлэх хэрэгтэй боллоо - гэв.

Өвгөн аажуухан босч, гэрэлт ясан толгойтой богино хар очроо тулан ойртов. Өндөр нас эзэн захирагчийг дарж байгаа нь илт боловч өндөр чилгэр, хүчирхэг баатар ван явсан нь илэрхий байв.

- Сайн уу чи, шидэт Гэндальф – гэж тэр хариулаад: - Гэвч чи надаас мэндийн үг сонсох гэж байгаа бол дэмий дээ. Чи тийм гавьяа байгуулаагүй. Чи дандаа л хар мэдээ авчирдаг. Чиний араас гай зовлон сүрэг сүрэг хэрээ шиг нисээд ирдэг. Худлаа яриад яахав. Аянга эзэнгүй хүрээд ирлээ гэж сонсоод би морио эргэж ирсэнд баярласан, тэгэхдээ чамаас салсандаа бүр ч их баярласан, Эомер чамайг эцсийн эцэст мөнхийн амар тайвныг олсон тухай мэдээ авчрахад би гуньж гутраагүй. Алсын цуурай худлаа байх юм даа. Чи дахиад л давхиад ирлээ! Чиний араас урьд өмнөхөөс ч аймшигтай гай зовлон дагаж ирнэ. Хар хэрээ Гэндальф чи надаас сайхан үг сонсмоор байна уу? Тэгвэл сонсохгүй!

Тэгээд тэр алтан ширээндээ лагхийн суув.

- Үнэн хэллээ эзэнтэн минь – гэж гишгүүр дээр сууж байсан хүнэрхүү юм хэлээд: - Чиний хүү Теодред ариун газарт амь үрэгдсэн тухай гашуудалт мэдээ аваад бид тав ч хоноогүй

байна. Чи Мустангримын хоёр дахь жанжингаа алдаад баруун гаргүй боллоо. Эомерт найдах хэрэггүй. Тэрнийг дур зоргоор нь тавибал чиний өргөөг ямар ч хамгаалалтгүй хаяж орхино. Гэтэл хар эзэн дайрах гэж байгаа тухай мэдээ Гондороос ирж байна. Энэ сахалт илбэчин дахиад л муу цагт ирж байна! Үнэхээр муу хар хэрээ чамайг ирлээ гэж бид баярлах болж байна уу? Хар хэлт гэж чамайг нэрлэе, ямар мэдээ авчирснаар нь элчийг үнэлдэг юм – гээд тэр бөлцгөр зовхио арайхийн өргөж, зочдыг муухай хараад инээхчээ аядав.

- Чамайг мэргэн зөвлөх гэдэг гэлүү, эрхэм Өмхий Ам аа, чи ч эзэндээ нээрэн гайхмаар найдвартай түшиг болдог юм байна даа - гэж Гэндальф тайвнаар өгүүлээд - Муу цагт зөвхөн илбэчингүүд ирдэггүй гэдгийг мэдэж ав. Муу мэдээтэй хамт урьд нь хэрэггүй байсан тусламж хөтлөлцөөд ирдэг юм.

- Байж болох л юм, - гэж Өмхий Амт егөөтэй хэлээд: - Гэвч бас бусдын зовлонд дуртай хүүр идэж, яс мэрэгчид ч байдаг юм. Хар хэрээ чи хэзээ тус хүргэж байсан юм бэ? Одоо чи ямар тус хүргэх гэж яарч ирэв?

Түрүүчийн удаа чи өөрөө тусламж гуйж ирсэн. Эзэн захирагч чамайг ивээж, морь сонгохыг зөвшөөрсөн, гэтэл чи Аянгыг сонгож бүгдийн дургүйг хүргээ биз дээ. Миний эзэнд хэцүү байсан боловч чи л хурдан далд орж байвал тийм өндөр үнэ төлөх юу ч биш байсан юм. Чи одоо ч гэсэн туслах гэж ирсэн биш, юм гуйх гэж л ирсэн. Чи дайчдаа аваад ирсэн үү? Тэгсэн бол бидэнд тус болох байсан юм. Гэтэл чи хэнийг авчирч байгаа нь энэ вэ? Гурван заваан өлөн юм дагуулаад ирж гэнэ, өөрт чинь гуйлгын хүүдий л дутуу байна!

- Чиний өргөөнд аянчдыг их л эвгүй угтдаг болж дээ, Тэнгэлийн хүү Теоден минь - хэмээн Гэндальф толгой сэгсрээд: - Хаалганы харуул миний дагуулуудын нэрийг хэлээгүй юм уу? Ийм хүндтэй зочид энэ өргөөнд ирж байгаагүй юм шүү, эд маань агуу их вангуудын эдэлдэг зэвсгээ үүдэнд чинь орхиод орж ирсэн. Энэ саарал өмсгөлийг Кветлориэний эльфүүд эд нарт бэлэглэсэн юм, чиний нийслэлд ирэх холын замд энэ хувцас олон аюулаас аварсан.

- Тэгэхлээр Алтан ойн илбэчин хүүхэн та нарыг ивээлдээ авсан гэж Эомер үнэн хэлжээ? – гэж Өмхий Амт шүднийхээ завсраар сийгүүлэн асуугаад: - Тэр ойлгомжтой, дандаа л ийм хог новштой орооцолдож байдаг юм.

Гимли урагш алхсан боловч Гэндальф мөрөн дээр нь гараа тавихад тэр дороо нам зогсов.

Өө Кветлориэн,

Үгүйрч хоосордоггүй,

Үхэж тоосордоггүй

Үүрдийн амьд гэгээтэй

Үнэт эрдэнийн хязгаар минь,

“Галадриэль! Галадриэль!” - гэж

Гал цэцэгс нь дуулдаг юм,

Газар ус нь түрж,

Гэгээн одод ирмэлцдэг юм.

Өө Кветлориэн минь,

Өмхийн тоос үгүй

Өнгө тунгалаг ертөнц минь!

– гэж Гэндальф дуулахад тэрбээр нүд ирмэх зуурт огт өөр болж, тамтаг хувцсаа тайлж шидээд, нуруугаа эгцлэн, очроо өргөж, ширүүн бөгөөд чанга дуугаар:

- Мэргэд бүдүүлгээрээ гайхуулдаггүй юм, Галмодын хүү Грим минь. Чиний дотор авах юмгүй илжирсэн байна. Өмхий амаа хамхи! Би ийм адгийн шаартай ам уралцах гэж галт үхлийн тогооноос гарч ирээгүй! – гээд очроо өргөн аянга буулгав. Нар туссан цонх харанхуйлж, өргөөнд өтгөн утаа манарав. Гал маналзан цог болж бөхөхөд ганцхан Гэндальф л тулганы дэргэд сүрлэг цагаан өмсгөлтэйгээ харагдаж байлаа. Харанхуйд Өмхий Амт:

- Би хэлсэн шүү дээ эзэн минь, энэний таягийг хураах байсан юм. Тэнэг урвагч Гайма биднийг хөөдлөө! – хэмээн үглэх сонсогдов.

Олон салаалсан цахилгаан гялсхийж, өргөөний дээвэр зад үсрэх шиг болов. Тэгээд нам гүм боллоо. Өмхий Амт толгойгоо даран нам хэвтжээ.

- Намайг сонс, Тэнгэлийн хүү Теоден,- гэж Гэндальф захирангуй хэлээд: - Чи гай зовлон ирэхэд тусламж хайсан биз дээ? – хэмээн очроороо өндөр цонх өөд заахад үүл сэмжирч, гүн цэнхэр тэнгэр харагдав.

- Дундад газрыг харанхуй бүрэн нөмрөөгүй байна. Эр зоригоо хөвчил, Мустангримын эзэн захирагч минь! – Энэ л чамд хамгийн найдвартай тусламж болно. Цөхрөхөд чих дүлийрдэг юм, цөхрөлөө авч хая, тэгвэл би чамд зөвлөгч больё. Гэхдээ нүд нүдээ харж байгаад ярилцъя. Эхлээд гадаа гарч, эргэн тойрноо хар. Чи цоожтой хаалганд бүгж, буруу зөрүү юм сонссоор мулгуу болж гүйцсэн байна.

Теоден суудлаасаа удаанаар босов. Өргөөнд гэрэлтэй боллоо. Бүсгүй өвгөн захирагчийг түшиж, өвгөн гишгүүрээр доош бугаад хөлөө чирэн асар том өргөөн дотуур гэлдрэв. Өмхий Амт хэвтсэн газраа хэвтсээр үлдлээ. Тэд хаалганд хүрч, Гэндальф очроороо хаалгыг дэлдэв.

- Нээгээрэй! Мустангримын эзэн захирагчид хаалга нээ! – гэж хашгирав.

Хаалга нээгдэж, цэвэр агаар өргөөнд сэвэлзэн оров. Уулын салхи чихнээ хүүгэж байлаа.

- Хамгаалагчдыг шатны хөл рүү явуул, бүсгүй минь чи ч гэсэн эзэн захирагчаа надад даатгаад орхичих – гэж Гэндальф хэлэхэд:

- Яв даа, эгчийн охин Эовин минь! Айдсын үе өнгөрлөө – гэж эзэн захирагч хэлэв. Бүсгүй эргэн явсан боловч үүдэнд очоод эргэж харлаа. Түүний харц ширүүн бөгөөд гүн бодолд автсан мэт харагдав. Тэр эзэн захирагч руу найдваргүй гунигтайгаар харж байв. Түүний царай ер бусын гоо сайхнаар туяарч, алтан шаргал гээг нь бүсэлхийдээ хүрч, мөнгөн бүстэй цагаан даашинз өмссөн гоо бие нь чилгэр хуснаас ч гоолиг, цэцгийн дэлбээнээс ч энхрий мөртөө гангаас ч хатуу, судсаар нь эзэн хаадын цус урсч байгаа нь илт байв.

Ристанийн гүнж Эовин Арагорнд анх удаа ийм л харагджээ. Тэрбээр навсархай саарал нөмрөгтэй өндөр аянчийг харангуутаа л их эрх мэдэлтэй эзэн хаан, баатар дайчин, олон жилийн үй олон бэрхшээл туулж, эр зориг, мэргэн ухааныг хослуулсан агуу хүн гэдгийг нь таньжээ. Гүнжтэн хоромхон зуурт түүнээс нүд салгалгүй ширтэж зогссоноо эргэж гарлаа.

- Эзэнтэн минь, улс орноо нэг хар даа! Цээж дүүрэн амьсгал! – гэж Гэндальф хэлэв.

Өндөр тавцан дээрх өргөөний үүднээс ширүүн урсгалт голын цаадах ногоон тал мананд умбаж үзэгдэнэ. Тал дээгүүр бороон хөшиг ташуулдан татжээ. Тэнгэрт аянгын бараан үүл хуралдаж, үл үзэгдэх алсын уулсын дээгүүр цахилгаан цахилж байв. Умрын салхи яаруухан уулгалж, дорноос ирсэн аянгын үүл өмнө зүг, тэнгис рүү нүүж байв. Гэнэт нарны хурц туяа үүлсийг ярж, аадар мөнгөрөн асгарч, голын мандал толь мэт гялалзав.

- Нарт ертөнц дээр тийм ч харанхуй болчихоогүй байна шүү - гэж Теоден дуугарахад:

- Харанхуй байна, гэхдээ нэгмөсөн харанхуй болчихоогүй. Чиний нас ч чамд шивнэсэн шигээр чамайг тэгж их дараагүй байна. Буруу үгийг хөсөр хая! – гэж Гэндальф өгүүлэв.

Эзэн захирагчийн хар очир гараас нь мултран унаж, тэр ядрангуй, удаанаар нуруугаа эгцлээд, өндөр чилгэр болон тэнийж, нүд нь тэнгэрийн гүн цэнхэр өнгөөр туяарав.

- Бүрхэг хар зүүд намайг дийлжээ. Гэвч одоо сэрэх шиг боллоо. Тийм ээ, Гэндальф, чи арай эрт ирэхгүй дээ. Чи хожимдож, нэгэн цагт Эорлын хүү Брегогийн бариулсан өндөр өргөөнд миний сүүлчийн өдрүүд, Мустангримын мөхлийг харах гэж л ирсэн байх вий гэж айж байна. Эртний нийслэлийн туурин дээр үнс үлдэх вий гэхээс айж байна. Гэлээ ч гэсэн чиний бодлоор бол яах ёстой вэ?

- Эхлээд Эомерийг авчир. Чи түүнийг чамаас бусад нь бүгдээрээ Өмхий Амт гэж нэрлэдэг Гримийн үгээр харанхуй нүхэнд хорьсон биз дээ?

- Тийм ээ, тэгсэн. Тэр миний үгэнд ороогүй, дээр нь миний хаан ширээний хөлд Гримийг хөнөөнө гэж занасан юм.

- Чиний үнэнч албат Өмхий Амтыг үзэн ядаж, тэрний зөвлөгөөг жигших эрхтэй - гэж Гэндальф хэлэв.

- Тийм ч байж магадгүй. Чиний хүссэнээр больё. Гаймаг дууд. Тэр найдваргүй хамгаалагч байгаа юм, даалгавар яаж гүйцэтгэхийг нь харъя. Хоёр бурууг нэг дор шийдье - гэж Теоден хэлэхэд түүний дуу хатуу сонсогдсон боловч Гэндальфын нүдийг хараад инээмсэглэхэд

түүний нүүрэн дээрх олон үрчлээ тэнийж оргүй алга болов.

Гаймаг дуудаж, Эомерийг авчруулахаар явуулсны дараа Гэндальф Теоденд чулуун суудлыг заагаад өөрөө шатны дээд гишгүүр дээр суув. Арагорн, Леголас, Гимли нар хажууд нь зогслоо.

- Удаан ярих цаг алга, гэхдээ чи олон зүйлийг мэдэхэд илүүдэхгүй. Удахгүй бид хоёр сайхан ярилцах завшаан тохиолдох ёстой. Харин одоо гай зовлон Өмхий Амтын чамайг айлгаснаас хавьгүй их гэдгийг чамд хэлье. Гэхдээ чи одоо нэгэнт сэргэлээ. Зөвхөн Гондор, Мустангрим хоёр бүх нийтийн дайсны эсрэг босоогүй. Тэрний хүч даанч их боловч тэрний мэдэхгүй нэг найдвар бидэнд байна.

Гэндальфын яриа хурдан болж, намуухан дуу нь ганцхан Теоденд л дуулдаж байсан бөгөөд эзэн захирагчийн нүд улам тод гялалзаж байв. Эцэст нь Теоден босч өндөр чилгэр биеэ эгцлэн зогсов. Гэндальф дэргэд нь зогсч, хоёулаа уулын өндөр дээрээс дорно зүг рүү харав.

- Үнэхээр тийм. Бидэнд аюул нүүрлэж байгаа тэр л газарт бидний аврал байна. Бидний хувь заяа хялгасан дээр дэнжигнэж байна. Гэвч цаг иртэл тэсч чадах юм бол аврагдах найдвар бий шүү - гэж Гэндальф чанга, тод хэлэв.

Гэндальфын гурван дагуул ч дорно зүг рүү харлаа. Нүд үл гүйцэх алс манан дунд умбаж байсан ч тэд санаа сэтгэлдээ уулсын саадыг давж, хүйтэн харанхуй нөмөрсөн тэр хязгаарт хүрч байлаа. Тэнд хаа нэгтээ бөгж хадгалагч яваа болов уу? Дээр нь бүх нийтийн хувь заяа дэнжигнэж байгаа тэр хялгас нарийхан шүү дээ! Холыг харагч Леголаст нэгэн зурвас гэрэл цацрах нь үзэгдэх шиг боллоо. Гондорын харуулын цамхгийн оройд нарны туяа ойлсон бололтой, тэртээ алсын харанхуйд бас нэг өчүүхэн хүрэн улаан гал хариу гялсхийх нь үзэгдэв.

Теоден суудал дээрээ дахин суулаа. Өтөл нас нь Гэндальфын санааны хүчийг даван эзэн захирагчийг дахин эзэмдэх шиг боллоо. Тэр өргөөгөө эргэж харав:

- Өтөл насанд минь гашуун өдрүүд ирлээ дээ! Би үлдсэн өдрүүдээ амар тайван өнгөрөөнө гэж найдсан юмсан. Эрэлхэг Боромир алагдаж! Залуус минь баатрын ёсоор амиа өргөж, хөгшид бид энэ насаа арай ядан чирч байна даа.

- Чи илднийхээ бариулаас атгавал гар чинь идэр залуугийн хүчээ эргэж санах болно - гэж Гэндальф өгүүлэв.

Теоден бослоо, гар нь илдээ эрж тэмтрэв. Илд нь байсангүй.

- Илдийг минь Грима хаана нуучихаа вэ – гэж тэр бувтнав.

- Май эзэнтээн! Энэ илд чиний нэрийн өмнөөс хуйнаасаа сугарлаа. Чи үүний эзэн – гэж хэн нэгний эрэмгий цовоо дуу хадав. Хоёр дайчин анзаарагдалгүй ирээд хэдэн алхмын цаана зогсчээ. Нэг нь Эомер байх бөгөөд хуяг дуулгагүй байв. Тэр хуйнаас нь сугалсан илд эзэн захирагчид өглөө.

- Энэ чинь юу болж байгаа нь энэ вэ? - хэмээн Теоден ширүүн асуув. Тэр Эомер руу сүрлэгээр эргэж харлаа. Түрүүхэн хаан ширээнд сууж байсан сул дорой өтөл өвгөн ор сураггүй болжээ.

- Миний буруу, эзэнтэн минь - гэж Гайма сандран хариулав: - Эзэн захирагч Эомерийг уучилж, чөлөөллөө гэж би бодсон юм. Би их баярласан, алдааг минь өршөөнө үү. Чөлөөлөгдсөн Мустангримын жанжин илдээ шаардахад би өгөхгүй байж чадсангүй.

- Би илдийг зөвхөн өлмий дор чинь өргөх гэж л авсан юм эзэнтэн минь – гэж Эомер өгүүлэв.

Теоден өвдөг сөхрөн бөхийсөн Эомер руу дуугүй харлаа. Бүгд хөдөлгөөнгүй зогсов.

- Илдээ авахгүй юм уу? - гэж Гэндальф асуух зөвлөхийн хооронд хэлэв.

Теоден гараа сарвайж, илдний бариулаас барихад гарт нь харсаар байтал баатрын хүч оров. Илд агаарт исгэрэн дугариг тойрог татлаа. Эзэн захирагч төрөлх хэлээрээ байлдааны уриа бардам сүрлэгээр хүнгэнүүлэн дуудав:

Теодений морьт дайчид аа,

Эзэн захирагч тулаанд дуудаж байна!

Нүдгүй харанхуйг гийгүүлэх цуст тулаанд мордьё!

Морьдоо эмээллэцгээ, бүрээгээ үлээцгээ!

Эорлингийн хөвгүүд урагшаа!

Хамгаалагчид шатаар пижигнэтэл гүйлдэн ирж, эзэн захирагчаа гайхаж, бахдан хараад илднүүдээ түүний өлмий дор тавилаа.

- Тушаалаа өгнө үү! – гэж тэд нэгэн дуугаар гуйв.

- Весту Теоден хал! – гэж Эомер чангаар дуу алдаж: - Бидэнд агуу их баяр ирлээ – агуу хүч сэргэхийг бид нүдээр үзлээ. Одоо чамайг дандаа хар муу хэл авчирдаг гэж хэлэхгүй байх аа, Гэндальф!

- Өөрийнхөө илдийг ав даа, эгчийн хүү Эомер минь! – гэж эзэн захирагч хэлээд: - Гайма, миний илдийг аваад ир: Грима хадгалж байгаа, Гримаг ч бас дагуулаад ир. Гэндальф чи миний зөвлөх больё гэсэн, зөвлөгөөг чинь сонсоогүй л байна шүү.

- Чи миний зөвлөгөөг аль хэдийн авсан, бузар ховонд авталгүй Эомерт итгэл хүлээлгэ. Айдас, харууслаа хөсөр хая. Юуг ч бүү хойш тавь. Байлдаж чадах эр бүгдийг Эомерийн зөвлөсний дагуу нэн даруй баруун зүгт мордуул: оройтоогүй дээр одоохон Саруманыг дарах хэрэгтэй байна. Чадахгүй бол бүх юм өнгөрнө. Чадвал цааш яах нь тодорхой болно. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшдийг Эдорасаас гаргаж, уулын нууц байранд оруул. Ийм үед л ашиглах гэж бэлтгэсэн шүү дээ.

Аль болохоор хурдан, аль болохоор их хүнсний нөөц, аль болохоор бага новш аваг, өөрсдөө л аврагдаж амжвал болох нь тэр.

- Чи ч үнэхээр лут зөвлөх юм аа, зэр зэвсгээ агсаад аян дайнд мордьё! Манайхан ч сайн эзэд юм аа! Аян замын улсыг ая муутай угтаж байна гэж чи үнэн хэлжээ Гэндалф. Та нар шөнөжин давхиж ирсэн, одоо үд болж байна. Идэж ууж, нойр авах хэрэгтэй шүү дээ. Одоохон байр бэлдэнэ, хоолны дараа унтаж амарцгаа.

- Үгүй ээ, эзэнтэн минь, унтаж амрах цаг алга, өнөөдөр Мустангримын морьт дайчид хөдөлнө, тэдэнтэй хамт бид гурав явна. Илд, нум сум, сүх гурав байна. Бидний зэвсэг танай үүдэнд хэвтээд юугаа хийхэв. Бидний илд хамтдаа гялалзана гэж би Эомерт амласан юм – гэж Арагорн өгүүлэв.

- Ялалт биднийх болно! - гэж Эомер баталлаа.

- Харж л байя, - гэж Гэндалф хэлээд – Изенгард бол аймшигтай дайсан, гэвч дараачийн дайн тулаанууд түүнээс зуу дахин аюултай. Бид тэдний урдаас хөдөлье, харин чи Теоден, үлдсэн хүмүүсийг бүгдийг нь Дунхэрийн хавцалд хүргэ.

- Үгүй ээ, Гэндалф! – гэж эзэн захирагч зөрөв: - Чи ямар эмч болохоо өөрөө ч мэдээгүй байна. Би Ристанийн дайчдыг удирдаж, тулалдааны талбарт бусдын адил үүргээ гүйцэтгэнэ. Тэгэхгүй бол санаа амрахгүй.

- За тэгвэл Мустангрим ялагдлаа ч гэсэн ялагчийн ёсоор магтан дуулах болно – гэж Арагорн хэлэхэд хажууд нь байгаа дайчид зэвсгээ хангинуулан:

- Удирдагч Теодений алдар бадартугай! Урагшаа, Эорлингийн хөвгүүд ээ! – хэмээн нижигнэтэл уриалав.

- Гэвч энд зэвсэггүй хүмүүсийг удирдагчгүй орхиж болохгүй, чи хэнийг захирагчаар томилох гэж байна? – гэж Гэндалф асуув.

- Би шийднэ, одоохондоо үгүй – гэж Теоден хариулаад: - Аа, миний нууц зөвлөх ирлээ - гэв.

Гайма өргөөний үүдэнд үзэгдэж, араас нь хоёр хамгаалагчийн дунд толгойгоо мөрөндөө шигтгэсэн Грима Өмхий Амт харагдав. Нүүр нь өвдсөн юм шиг ярвайж, наранд дасаагүй нүд нь зогсолтгүй анивчина. Гайма өвдөг сөгдөн, эрдэнийн чулуун шигтгээтэй алтадмал хуйтай урт илдийг Теоден өргөн барив:

- Эзэнтэн минь, чиний эртний илд Геругрим – гэж тэр хэлээд: - Тэрний авдарт байна, тэр авдраа онгойлгохгүй гэж их үзэлцлээ. Тэр авдарт алга болсон юм олон байна.

- Чи худлаа ярьж байна. Эзэнтэн илдээ надад хадгалуулсан юм – гэж Өмхий Амт могой шиг исгэрэн хэлэв.

- Одоо эзэнд нь эргүүлж өгөх хэрэгтэй. Чи хүний юмыг өгөх дургүй юм аа – гэж Теоден хэлэв.

- Бүгдийг чи мэднэ, эзэнтэн минь. Би зөвхөн чамайг болоод чиний хөрөнгийг хамгаалдаг. Биеэ гамнаарай, хүчээ нөөгөөрэй, урьдынх шигээ биш болсон шүү. Яршигтай гийчдийг өөр хүнд хариуцуул. Хоол чинь бэлэн болсон. Ширээнд морилно уу?

- Морилно оо, миний зочдод хоол унд бэлд, бид хамт сууж хооллоно. Дайчид өнөөдөр мордоно. Хот болоод ойр хавийн суурингаар элч нарыг довтолго. Зэвсэг барьж чадах, морьтой эрчүүдийг үдийн хоёр цагт хаалган дээр бэлэн байлга!

- Ээ эзэнтэн минь! Энэнээс л би айгаад байсан юм. Илбэчин чамайг илбэдчихэж. Чи эцэг өвгийнхөө алтан өргөөг, эд хөрөнгөө харуул хамгаалалтгүй орхих нь уу? Манай хязгаарын эзэн хамгаалалтгүй үлдэх нь үү?

- Илбэдсэн гэв үү чи? - гэж Теоден асуугаад: - Ийм илбэ надад чиний шивнээнээс эрхэм байна. Чиний халамжаар бол би аль хэдийн дөрвөн хөллөөд мөлхөж байх байлаа. Үгүй ээ, Эдораст хэн ч үлдэхгүй. Нууц зөвлөх Грима хүртэл дайнд мордоно. Яв! Илдний зэв арилгах зав чамд байгаа биз дээ.

- Өршөөж хайрла, эзэнтэн минь! Чиний төлөө зүтгэсээр байгаад зөнөсөн өвгөн намайг хайрлаж үз! Намайг битгий явуул! Би ганцаараа эзний өргөөг хамгаалж чадна. Үнэнч боол Гримагаа битгий явуул! – гэж Өмхий Амт эзний хөл дор эвхрэн орилов.

- Өрөвдье, өрөвдөөд явуулахаа больё - гэж Теоден хэлээд: - би цэргээ захирч явна. Чи надтай хамт тулалдаж үнэнчээ нотлон харуул.

Өмхий Амт буланд шахагдсан араатны харцаар эргэн тойрноо харж, авралын олс хайна. Тэр урт ягаан хэлээрээ цорвогор уруулаа долоолоо.

- Ийм шийдэмгий төрх хичнээн хөгшин ч гэсэн Эорлын удмын эзэн захирагчид зохиж байна аа, гэвч үнэнч зарц би өндөр насаа бод гэж түүнээс гуйх нь мэдээж. Гэвч би хожимдсоноо харж байна, миний эзэнтэн өөрийнх нь цагаасаа эрт үхэлд харамсан гашуудахгүй этгээдүүдийн үгэнд орсон нь илт байна. Энд би юугаар ч тус болж чадахгүй, гэвч миний сүүлчийн зөвлөгөөг сонс, эзэн минь! Эндхийн захирагчаар чиний нууц санааг мэддэг, чиний зарлигийг ариунаар шүтдэг нэгнийг тавь! Эргэж ирэх чинь хичнээн найдвар муутай ч гэсэн өөрийг чинь иртэл Эдорасыг хамгаалах үүргийг үнэнч бөгөөд их туршлагатай Гримад даалга – гэж тэр арга сүвэгчлэв.

Эомер тачигнатал хөхрөв.

- Өө анхаарал халамжтай Өмхий Амт аа, хэрэв энэ хүслээс чинь татгалзвал чи яах вэ, дайнд л явахгүй бол бүр бага юмыг ч зөвшөөрнө биз дээ? Шуудай гурил уул өөд үүрч гаргах юм уу? Даанч чамд итгэж шуудай гурил өгөхгүй л дээ!

- Үгүй ээ, Эомер, чи хүндэт зөвлөхийн далд санааг ойлгохгүй байна – гээд Гэндальф Өмхий Амт руу нэвт шувт ширтэж:

- Тэр их зальтай, азаа туршсан тоглоомоор тоглож байна, бүр одоо ч хожиход ойрхон байна.

Энэ одоо миний хичнээн үнэт цагийг хожчихоод байна вэ! Хэвтээд, муу хорт могой! Хэвт, элгээрээ мөлх! Чи Саруманд эрт худалдагдсан уу? Чамд тэр юу амласан бэ? Бүх дайчид тулалдааны талбарт унахад чи өөрийн шан харамж эрдэнэсийг аваад дээрээс нь өдрийн бодол шөнийн зүүд болж явдаг эмэгтэйг авах уу? Чи хэдэн жил түүний араас далдуур, хомхой амаа долоон мөшгөж байгаа шүү дээ.

Эомер илдээ шүүрэв.

- Энэнийг би урьд нь ч мэдэж байсан юм, тэгээд л алтан өргөөнд, эзэн захирагчийн өмнө, эртний хуулийг зөрчин цавчихад бэлэн байсан. Тэгэхлээр энэ бас урвагч байх нь ээ? – гээд урагш алхахад Гэндальф түүнийг зогсоов:

- Эовинд одоо аюулгүй, харин чи Өмхий Амт... чи өөрийнхөө жинхэнэ эзэнд чадах бүхнээрээ зүтгэсэн, тэр чамд өртэй, гэвч Саруман мартамхай, өр өгөхдөө дургүй. Хурдхан тэрэн дээр явж очоод байгуулсан гавьяагаа сануул, тэгэхгүй бол хоосон хоцорно шүү.

- Чи худлаа ярьж байна – гэж Өмхий Амт гуншив.

- Чиний амнаас энэ үг салдаггүй нь дэмий хэрэг биш байх. Үгүй шүү би худлаа хэлээгүй. Хараач Теоден, жинхэнэ хорт могой! үүнийг дэргэдээ байлгах аюултай, энд орхиж ч болохгүй. Цаазалчихад л болох юм, гэвч чамд олон жил чаддагаараа л зүтгэсэн юм даа. Морь өгөөд харсан зүг рүү нь явуулчих. Тэрний сонголт шийтгэл нь болог.

- Сонсов уу, Өмхий Амт аа? Сонголтоо хий. Нэг бол надтай хамт явж тулалдан үнэнч гэдгээ ирт зэвсгээр нотол, эсвэл дуртай зүг рүүгээ тонил. Харин дахиад уулзвал надаас ивээл битгий горьдоорой.

Өмхий Амт удаанаар босч, хүмүүсийг тойруулан харснаа Теоденд нэг юм хэлэх гэж амаа ангайснаа болив. Махийсан хуруунууд нь чичирч, нүдэнд нь хорсол дүрэлзэн, нүүрээ ярзайлгаад эзэн захирагчийн хөл доор чанга гэгч нулимчихаад ухасхийн шатаар уруудав.

- Араас нь дага! Хорон юм хийж магадгүй, гэхдээ гар хүрч хэрэггүй, барьсны ч хэрэггүй. Морь авах гэвэл өгчих – гэж Теоден тушаав.

- Ийм амьтан нуруун дээрээ гаргах морь байхгүй л байх аа даа – гэж Эомер хэлэв.

Хамгаалагчдын нэг нь доош гүйж, нөгөө нь дуулгандаа булгийн ус авчран Өмхий Амтын бузарласан чулуун хавтанг угаалаа.

- За одоо ёстой жинхэнэ тавтай морилцгооно уу! Түргэхэн хооллох зуураа жаахан ярилцъя - гэж Теоден урилаа.

Тэд өргөөнд эргэж оров. Тэртээ доор, элч нарын хашгирах, байлдааны бүрээ үлээх сонсдож, эзэн захирагчийн зарлигийг дамжуулан дайчид цугларч эхэллээ. Зоогийн ширээнд Теодений дэргэд Эомер болон дөрвөн зочин суулаа. Эзэн захирагчид Эовин үйлчилж байна. Дуугүйхэн, хурдан идэж ууж, зөвхөн эзэн Гэндальфаас Саруманы тухай асууж байв.

- Тэр урваснаас хойш би түүний тухай мэдэхээ больсон. Хар хор тэрнийг аажмаар идсэн. Нэгэн цагт тэр танай жинхэнэ анд байсан гэдэгт би итгэдэг, тэр үед ч гэсэн хар санаа нь боловсорч, сэтгэл зүрх нь хатуурч байсан, Мустангрим эхэндээ тэрэнд саад болоогүй, хэрэгтэй ч байсан байж магадгүй. Гэвч энэ бол эртний явдал, тэр эртнээс та нарыг хөнөөх санаа агуулж, сайн хөршийн дүр эсгээд хүчээ хуримтлуулж байсан. Тэр жилүүдэд Өмхий Амт Изенгард руу чиний бүх ажил хэрэг, бодол санааг шууд л мэдээлдэг байсан. Тэрэнд энэ амархан байсан. Харийнхан байнга нааш цааш хөлхөж, Ристани нээлттэй байсан учир хэн ч анзаардаггүй байсан. Дээрээс нь тэр үргэлж зөвлөж, чагнаж, чиний сэтгэл санааг хордуулан, сэтгэлийг чинь хүйтрүүлж, зоригийг чинь мохоодог байжээ. Чиний албагууд тэрийг нь ил харж байсан ч яаж ч чадахгүй байсан, яагаад гэвэл чи тэрний амаар ярьдаг болсон.

Гэвч би Ортханкаас аврагдан чамайг сэрэмжлүүлэхэд баг нь хуулагдаж, нууц нь ил гарсан. Тэгээд Өмхий Амт аюултай заль хэрэглэж эхэлсэн. Тэр хамгаалалт хийж, цохилтоос булгаж байсан. Дайчид өрнө газарт хэрэгтэй байхад тэрний хэлснээр бүх дайчдаа умар зүг илгээснээ санаж байна уу? Эомер орхуудыг хөөх гэхэд тэр чиний амаар болиулсан. Хэрэв Эомер чиний тушаалаас зөрөөгүй бол орхууд одоо Изенгард руу үнэлж баршгүй их олзтой очих байсан. Саруманы мөрөөдөж байгаа тэр олз биш, нууцхан найдварт маань хамаатай манай багийн хоёр гишүүнийг аваад очих байсан, энэ тухай би чамтай ч гэсэн ил ярьж болохгүй байна, эзэнтэн минь. Зөвхөн тэр хоёр хичнээн их зовлонг тэсч гарсныг, хэрэв Саруман тэднийг мэдсэн бол бидэнд ямар их гай тохиолдохыг л бодоод үз.

- Би Эомерт их өртэй, үг нь хатуу ч үнэнч зүрхтэй гэж ярьцгаадаг юм.

- Буруу шүүх зөвийг буруутгадаг гэж хэлсэн нь ононо гэж Гэндальф засав.

- Тийм ээ, би буруу шүүж байсан, чиний зөнд бас өртэй би. Чи дахиад л цагаа олж ирлээ. Чиний хүссэнээр бэлэг өргөхийг зөвшөөрнө үү? Чи юу л хүснэ, тэр чинийх. Миний илдийг л надад үлдээгээрэй!

- Цагаа олж ирсэн эсэхийг одоо бид үзнэ. Харин чамаас бэлэг дуртайяа авна. Аль хэдийн сонгочихсон. Аянгыг надад бэлэглэхих! Чи түүнийг надад зээлдүүлсэн шүү дээ – тэгж тохиролцсон. Харин одоо би түүнийг унаж, үзэж хараагүй аймшгийн өөдөөс давхина. Нэг мөнгөн цагаан морь есөн хөө хар морины урдаас. Аянга бид хоёр аль хэдийн ах дүү мэт болсон ч хүний мориор дэнчин тавиад яахав.

- Зөв сонголт байна, миний сүргийн тэргүүн морийг чамд бэлэглэхдээ би баяртай байна, Аянга шиг морь өөр байхгүй, цаашид ч төрөхгүй болов уу гэж айж байна. Ганцхан түүнд л эртний агуу үүлдэр биеллээ олсон юм. Харин бусад гурван зочин миний зэвсгийн сангаас бэлгээ сонгоорой. Илд та нарт хэрэггүй, гэвч Гондорын гайхамшигт дархчуудын урласан хуяг дуулганууд байгаа. Таалагдсанаа аваарай, дайн тулаанд та нарын амь биеийг хамгаалах болтугай!

Зэвсгийн сангаас тэр даруйд олон хуяг дуулга авчрахад Арагорн, Леголас хоёр гялалзсан хөө хуяг, эрдэнийн чулуун шигтгээтэй, алтан хээтэй дуулга, бамбай өмслөө. Гэндальфт хуяг дуулганы хэрэг байхгүй, Гимлид Уулын доорх хант улсын гном дархчуудын урласан хуягнаас нь бөх хуяг Эдорасын зэвсгийн санд байсангүй. Гэвч тэр арьсан дотортой ган дуулга сонгож

авахад бөмбөг толгойд нь ургаа юм шиг таарав. Бас Эорлын сүлд – ногоон талд давхиж яваа цагаан морины дүрстэй жижиг бамбай авлаа.

- Чамайг сум, илд, жаднаас хамгаалах болтугай! Энэ бамбайг эцэг Тэнгэл минь намайг хүүхэд байхад надад хийлгэсэн юм – гэж Теоден хэлэхэд Гимли гүнээ мэхийв.

- Би чиний сүлдийг гутаахгүй ээ, Ристаниин эзэн минь, надад морь унаж давхиснаас морьтой бамбай барьж гүйсэн нь дээр. Өөрийн хөл арай найдвартай. Намайг хэрэгтэй газар аваачаад хатуу газар дээр буулгахад би өөрийгөө харуулна.

- Харья даа - гэж Теоден инээмсэглэв.

Эзэн захирагч босоход Эовин түүнд том хундагатай дарс барьж:

- Фэрту Теоден хал! Энэ сайхан хоромд энэ дарсыг тогтооно уу. Аз чамд жигүүр ургуулж, ялан дийлээд ирээрэй! – гэж ерөөв.

Теоден дарснаас балгаад өгөхөд Эовин зочдод барилаа. Арагорны өмнө зогсоод оч цацарсан нүдээрээ түүний нүд рүү ширтэв. Арагорн бүсгүйн гоо царай руу инээмсэглэн хараад хундагыг авахдаа түүний чичирхийлсэн гарт санамсаргүй хүрчихэв.

- Чамд ялалт ерөөе Араторны хүү Арагорн!

- Чамд ч бас Ристаниин гүнжтэн, - гэж тэр хариулаад, инээмсэглэл нь алга болж баргар царайлав. Дарсыг тойруулан ууж дуусаад эзэн захирагч түрүүлэн өргөөнөөс гарлаа. Тэнд өргөөний хамгаалагчдаас гадна бүрээ барьсан зарч нар, Эдорас болон ойр хавийн суурингуудын ноёд цугларчээ.

- Би аян дайнд мордлоо, миний эриний сүүлчийн тулалдаан ч байж магадгүй. Миний хүү Теодред бурхан болсон, хаан ширээг шууд залгамжлагч байхгүй. Миний эгчийн хүү Эомер намайг залгамжилна. Хэрэв тэр эргэж ирэхгүй бол эзэн захирагчаа өөрсдөө сонгоорой. Одоогоор дайны цагт Эдорасын захирагчийг томилох хэрэгтэй. Та нарын хэн чинь миний захирагч болох вэ?

Нэг ч хүн хариулсангүй.

- Хэн ч алга уу? Миний ардууд хэнд илүү итгэдэг вэ?

- Эорлын гэр бүлд - гэж Гайма бүгдийн өмнөөс хариулав.

- Эомерийг би үлдээж чадахгүй, тэр өөрөө ч үлдэхгүй – гэж эзэн захирагч хэлэв.

- Тэр танай гэр бүлийн сүүлчийн хүн үү?

- Би Эомерийг нэрлээгүй, тэр гэр бүлийнхээ сүүлчийн хүн биш. – гээд Гайма - Түүнд Эомундын охин Эовин гэдэг эгч байгаа. Тэр бол цэвэр ариун сэтгэл зүрхтэй, айдас гэгчийг мэдэхгүй. Тэр Эдорасын жолоог гартаа аваг, тэр тогтоож чадна.

- Тэр ёсоор болог - гэж Теоден батлаад: - Зарчид миний захирагчийн нэрийг ардуудад зарла!

Тэгээд эзэн захирагч хаалганы дэргэдэх суудал дээр суугаад өвдөг сөгдсөн Эовинд илд, үнэт эрдэнийн хуяг дуулга гардуулав.

- Баяртай эгчийн охин минь! Бид бэрх цагт хагацаж байна, гэвч алтан өргөөндөө дахиад уулзаж магадгүй. Хэрэв уулзахгүй бол, үлдсэн дайчид маань Дунхэргийн хавцалд ирнэ. Тэнд та нар удаан тэснэ.

- Наад үг чинь дэмий үг. Гэвч та нарыг эргэж иртэл надад өдөр бүр жил шиг санагдах байх – гээд Эовин дэргэд нь зогсч байгаа Арагорн руу харлаа.

- Эзэн захирагч эргэж ирнэ ээ, санаа бүү зов! Үхэх сэхэхээ үзэх байлдаан биднийг баруун зүгт биш, дорно зүгт хүлээж байгаа! – гэж Арагорн хэлэв.

Теоден, Гэндалф хоёр урт мушгиралдсан шатаар уруудах жагсаалыг тэргүүлэв. Цайзын хаалганд хүрээд Арагорн эргэж харлаа. Өндөр дэвсэг дээрх алтан өргөөний үүдэнд Эовин хоёр гараараа илдээ тулан зогсоод тэднийг харж байв. Алтлаг хуяг дуулга нь наранд гялалзана.

Гимли мөрөн дээрээ сүхээ тавиад Леголасын дэргэд алхаж явна.

- Арай гэж нэг юм хөдөллөө! Энэ хүмүүс гэдэг чинь бүх юмны тухай яриад л байх юм, яриад л байх юм. Гэтэл миний гар загатнаад сүхээ эргүүлээд баймаар. Ристаничууд ч сайн цавчдаг л даа. Гэхдээ л энэ дайн надад таалагдахгүй байна. Байлдааны талбар нь хаана ч байдаг юм, байлдах гэж байгаа юм бол яваад л хүр гэх юм. Явган явдаг бол ч бас яая гэхэв, гэтэл шуудайтай юм шиг л Гэндалфын эмээл дээр сэгсчүүлнэ шүү дээ.

- Атаархмаар суудал байна даа, гэхдээ санаа бүү зов, Гэндалф чамайг хэрэгтэй газар чинь буулгана, Аянга түүнд үүний төлөө баярлалаа гэж хэлнэ. Морин дээрээс яаж сүх эргүүлэх юм бэ.

- Гномууд морин дээрээс тулалддаггүй. Морин дээрээс хүмүүсийн шилэн хүзүүний үсийг л хусна уу гэхээс орхуудын толгойг цавчих боломжгүй – гэж Гимли хэлээд сүрт сүхнийхээ ирийг илэв.

Хаалганы дэргэд морьт дайчид жагсчээ. Залуу хөгшин бүгд бүрэн зэвсэг агсан, мориндоо мордсон байна. Мянга гаруй дайчид жадныхаа үзүүрийг ярайтал өргөн Теоденийг гарч ирэхэд баяртайгаар уриалан хашгирч, Цагаандэлт морийг нь авчирч өглөө. Арагорн, Леголасын хоёр морьд ч бэлэн зогсч байна. Гимли ганцаараа үлдээд уурлах аястай хушуу цорвойтол Эомер морь хөтлөн хүрч ирэв.

- Сайн уу, Глоины хүү Гимли! Чамаас эелдэг харьцаа сурах зав гарахгүй байгааг харж байгаа биз дээ. Одоохондоо хэл амаа билүүдэх болих уу? Алтан ойн хатан хааны талаар нэг ч эвгүй үг хэлэхгүй гэдгээ амлая.

- Би тооцоогоо хойш тавихад бэлэн байна, Эомундын хүү Эомер, гэвч чи хатан хаан Галадриэлийг нүдээр харах завшаан тохиолдвол нэг бол түүнийг ертөнцийн хамгийн сайхан эмэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрнө, эсвэл надтай халз тулаанд гарна.

- Тэгэх болтугай! Тэр болтол миний бодлогогүй хэлсэн үгийг уучил, тэгээд уучилсны тэмдэг болгож надтай хамт явахгүй юу, Гэндалф эзэн захирагчтай түрүүлж явна, миний морь Галхөлөг чи бид хоёрыг дуртайяа авч явна.

- Баярлалаа, зөвшөөрч байна – хэмээн эелдэг ярианд нь сэтгэл хангалуун Гимли хэлээд: - Харин миний анд Леголас бидний хажууд яваг.

- Шийдлээ! – зүүн талд Леголас, баруун талд Арагорн яваг. Бид дөрвийн өөдөөс тэсэх дайсан байх уу?

- Аянга хаачив? – гэж Гэндалф асуув.

- Голын эрэгт идээшилж яваа, хэнийг ч ойртуулахгүй байна. Тээр тэнд, гармын ойролцоо бургасан дотор.

Гэндалф нэг чанга исгэрээд нэрээр нь дуудахад Аянга хариу үүрсээд нүд ирмэх зуурт давхиж ирэв.

- Мах цусанд нь өрнийн салхи хүүгэж байна даа – хэмээн Эомер гайхамшигт хөлгийг бахдан харангаа хэлэв.

- Бэлэглэхгүй байж яаж болох билээ - гэж Теоден хэлээд дуугаа өндөрсгөж: - Бүгд сонсоцгоо! Мэргэн зөвлөх бөгөөд эрэлхэг дайчин Саарал Гэндалфыг бүгд мэдэж авцгаа, одооноос эхлэн манай хүндэт зочин, Ристаниин түшмэл, Эорлийн хөвгүүдийн замыг заагч болно. Эорлын алдар бөхөөгүй цагт миний үг эвдэршгүй! Түүнд Мустангримын адуун сүргийн манлай Аянгыг бэлэглэлээ!

- Баярлалаа чамд эзэн захирагч Теоден – гээд Гэндалф навсархай цув, өргөн хүрээт бүрхээ авч хаяв. Тэр хуяг дуулгагүй, цагаан өмсгөл, буурал үс нь цасан өнгөөр гялалзаж үзэгдэв.

- Бидэнтэй хамт Цагаан морьтон явж байна! – гэж Арагорн хашгирахад дайчид уухайлан түрлээ.

- Эзэн захирагч, Цагаан морьтон хоёр бидэнтэй хамт явж байна! Эорлийн хөвгүүд урагшаа! – хэмээн эгнээ эгнээ жагсаал хүнгэнэн цуурайлав.

Бүрээнүүд уртаар уянгалан хүнгэнэв. Морьд байж ядан цоройж, янцгаалдлаа. Илд жаднууд бамбайгаа дэлдэнэ. Эзэн захирагч гараа өргөхөд хүчит шуурга Ристанийн сүүлчийн армийг хийсгэн одох шиг аяндын их үүл баруун зүг довтлон одов.

Эовин хоосорсон алтан өргөөний үүдэнд ганцаар зогсоод ногоон талд гялалзах жаднуудын алсын гялбааг харж байвай.

Бүлэг 7

Хельмагийн хавцал

Эдорасаас гарахад нар баруунаа ташиж, нүд гялбуулан, баруун талаар цэлийх Ристанийн тэгш талд алтлаг манан татаж байлаа. Тод өргөн зам нэг дээш өгсч, нэг доош уруудан түргэн урсгалт гол горхинуудыг гаталсаар алс өрнө рүү оджээ. Тэртээ баруун хойт зүгт Манант уулс үзэгдэж улам тодорсоор. Орой болов.

Их цэрэг бараг зогсолгүй хурдалсаар. Хожимдохоос эмээж морьдоо шавдуулан давхиж байв. Морьд нь Дундад газарт байхгүй хурдан бөгөөд тэсвэртэй боловч зам хол, Эдорасаас Изенгардын гарам хүртэл шууд явахад элбэг дөчин бээр, замаар явахад зуун дөчин бээр байв. Шөнө болоход дайчид сая зогслоо. Таван цаг гаруй давхисан ч замынхаа хагасыг ч туулаагүй байв. Оддын гэрэл, бүдэг сарны туяанд өргөн хүрээ болж, хоноглов. Гал түлсэнгүй, эргэн тойронд харуул гаргаж, тагнуулчдыг илгээв. Урт, тайван шөнө өнгөрч, үүрээр бүрээнүүд цуурайлан дайчид замаа хөөв.

Үүлгүй мөртөө бараантаж, бүгчим байв. Нар утаа манан дундаас хөөрсөн боловч араас нь аянгын үүл нөмрөх мэт тэнгэр харанхуйлж байв. Баруун хойноос, Манант уулсын бэлээр бас л харанхуй нөмөрч угтав. Гэндальф жолоогоо татаж, Леголастай зэрэгцэв.

- Чиний нүд холч, Леголас, эльфүүд та нар хоёр бээрийн газар байгаа болжморыг таньдаг шүү дээ. Чи Изенгард хүрэх замд ямар нэг юм үзэж байна уу?

- Изенгард хүртэл хол байна шүү, - гээд Леголас урт гараа духандаа хүргэн саравчлав: - Бидний замыг харанхуй бүрхсэн байна, голын эргээр харанхуйд ямар нэг асар том сүүдрүүд найгаж байна, юун сүүдэр болохыг бүү мэд. Би харанхуйг ч, мананг ч нэвт хардаг, гэтэл ямар нэг далдын хүчээр нэвтэршгүй хөшиг татчихаад байна. Уулнаас ойн харанхуй мөлхөж буугаад байгаа юм шиг.

- Ингээд Мордороос аянга бууна, аймшигтай шөнө болох нь дээ - гэж Гэндальф хэлэв.

Улам л бүгчим болж, орой болоход тэнгэрийг хаасан хар үүл тэднийг гүйцэж өмнө нь гарлаа. Цусан улаан нар утаан харанхуйд живэв. Цагаан уулын хойт үзүүр ойртож, гурван оргилт Трайгирны оройд нарны туяа тусан, Ристанийн дайчдын жаднууд улаан туяа ойлгож байв. Толгойн сэргийлэхийн дайчид нэг хар цэг харж, тэр нь толбо болон томорсноо нэгэн морьтон жаргах нарны хүрэн туяан дотроос сугаран давхиж ирэв. Дайчид түүнийг хүлээн зогслоо.

Цавчигдсан дуулга, бамбайтай, ядарсан царайтай дайчин мориноос бууж, найган зогсоод:

- Эомер та нартай яваа юу? Яаж ийгээд давхиад ирлээ, оройтсон ч гэсэн, гэхдээ та нар их цөөхөн байна даа. Теодредоос хойш бидний ажил хэрэг өөдлөхөө байж дээ – гэж тэр сөөнгөтөн хэлээд: - Өчигдөр бид Изенгээс ухарсан, олон дайчин гарам дээр амиа өргөлөө. Шөнө дайсны гол хүч ирсэн, тэгээд шинэ хүчээр сэлбээд манай эрэг рүү дайрлаа.

Изенгардын бүх хар хүч энд бөөгнөрсөн, тэдэнд тоо байхгүй, дээр нь Саруман уулын зэрлэгүүд Дунландаас ирсэн нүүдэлчдийг зэвсэглэсэн байна. Нэг хүнд арав ногдож байна. Тулгуур цайзыг дайрч авсан. Вестфольдын Эркиенбранд чадах бүх хүнээ цуглуулаад Чөтгөрийн хавцал дахь цайзад хориглосон. Бусад нь хандсан зүг рүү тарж одлоо. Эомер хаа байна? Түүнд хэл: Бүх юм өнгөрсөн. Эдораст эргэж очоод Изенгардийн чонодолоохуудыг хүлээ гэж дамжуул. Удаан хүлээхгүй дээ.

Теоден хамгаалагчдынхаа ард зогсоод дуугүй сонсч байснаа морио давиран урагш гарав.

- Чамайг нэг хараадахья даа, Сэорл! Би Эдораст биш, энд байна. Эорлингийн сүүлчийн арми аян дайнд мордсон, тулалдахгүйгээр буцахгүй.

Дайчны царай гайхаж, баярласандаа гэрэлтээд явчихав. Тэр нуруугаа эгцэлж, өвдгөө бардмаар нугалсхийгээд эзэн захирагчид ир нь эмтэрсэн илдээ сунгаж:

- Тушаалаа өгнө үү, эзэнтэн минь! Намайг өршөөгөөрэй! Би бодохдоо...

- Чи намайг Медусельдэд цасанд дарагдсан мод шиг өмхөрч байгаа гэж бодсон уу? Үнээн, чамайг тулаанд мордоход би тийм байсан. Харин одоо тийм биш: Өрнийн салхи миний дээрх цасыг сэгсэрч хаясан. Түүнд сэлгээ морь өг! Эркиенбрандыг аврахаар давхицгаая! Тэр хооронд Гэндальф урагш явж, утаа манан дундаас үл үзэгдэх Изенгард руу саравчлан харж байв. Тэгснээ яаран давхиж ирээд:

- Цэргээ аваад яв, Теоден! Хурдхан Хельмагийн хавцал руу эргэ! Изений гарам дээр та нарт хийх юм байхгүй. Надад өөр яаралтай ажил гарлаа – Аянга намайг аварна! - гэснээ Арагорн, Эомер болон хамгаалагчид руу хандаж: - Юу ч боллоо гэсэн эзэн захирагчийг хамгаалаарай! Намайг Хельмагийн хавцалд хүлээж бай! баяртай!

Тэр Аянгын чих рүү тонгойж нэг юм хэлэхэд нумнаас сум тавих мэт мөнгөлөг дүрс гялсхийгээд, салхи исгэрч бараа сураг алдрав. Цагаандэлт түүний араас үүрсэн цоройсон боловч Аянгыг хамгийн хурдан шувуу ч гүйцэхээргүй холдон одсон байв.

- Энийг чинь юу гэж ойлгох болж байна? – хэмээн нэг хамгаалагч Гаймагаас асуулаа.

- Саарал Гэндальф хаа нэг тийшээ маш яарч байна гэж л ойлгохоос. Энэ Гэндальф гэнэтхэн л хаа нэгтээгээс гараад ирдэг, хаа нэг тийш алга болдог юм.

- Өмхий Амт энд байсан бол тэр тайлбарлаад өгөх байсан даа

- Тайлбарлах байсаан, гэвч миний хувьд Гэндальфыг хүлээсэн нь дээр байх аа, учир нь аяндаа олдоно.

- Хүлээ хүлээ, ирэх ч юм билүү

Их цэрэг өмнө зүг рүү огцом эргэж, шөнийн талаар давхилаа. Уулс тун их ойртсон боловч Трайгирны өндөр оргилууд харанхуй тэнгэрт дөнгөж үзэгдэх төдий байлаа. Вестфольдын хөндийгөөр Хельмагийн хавцлаас эх авсан нэгэн гол урсах бөгөөд Хавцлын гол нэртэй ажээ.

Хавцлыг Хельмагийн хавцал гэх бөлгөө. Эрт цагт Хельма нэрт дайчин захирагч энд маш удаан хугацаагаар хориглон байлдсан тул ингэж нэрлэжээ. Нарийхан, гүн, тахиралдсан хавцал Трайгирны хажууг огтлон хойт зүгт рүү одож, эцэст нь хоёр талын хадан хясаа хавцлын дээгүүр бараг нийлдэг ажээ.

Хавцлын хойт үзүүрт асар зузаан чулуун ханатай эртний цамхаг байх бөгөөд домогт өгүүлснээр бол, Гондор улс мандан бадарч байх үедээ титануудаар бариулсан гэх аж. Горнбург нэртэй цайзын өндөр дээрээс бүрэн дуу арын хавцалдаа зуу дахин цуурайлах учир агуйд оршсон эрт цагийн тоолшгүй олон дайчид туслахаар ирж яваа мэт сонсогддог бөлгөө.

Эртний тэр барилгачид хавцлыг Горнбургаас өмнөд хадан хясаа хүртэл заагласан ба ханан доогуурх том усан сангаас Хавцлын гол эх авчээ. Эдүгээ Горнбург Вестфольдын захирагч, баруун хилийн жанжин Эркенбрандын түшиц газар болсон байна. Их туршлагатай, алсын хараатай тэр жанжин сүүлийн жилүүдэд цайзын ханыг сэргээн барьсан ажээ.

Дайчид хөндийгөөр давхиж байтал, эхний эгнээнд хашгиралдах сонсдож, бүрэнүүд хангиналаа. Тэгснээ харанхуйд сум исгэрэлдэв. Дараа нь тагнуулчид давхилдан ирэв. Хавцлаар чонодолоох унасан орхууд холхиж, хойт зүгээс, Изенгардын гармаас тоомшгүй олон дайсан хавцалд дөхөж байгааг дуулгав.

- Тэнд манай олон дайчид ганц хоёроороо алагдсан байна. Энд тэнд хэсэг бусгаараа хориглож байна, гэхдээ удирдлага алга. Эркенбренд ясныг хэн ч мэдэхгүй байх шиг байна. Хельмагийн цайз хүртэл тэр мэнд очиж чадахгүй л болов уу, алагдчихсан ч байж мэднэ.

- Гэндальфыг хараагүй биз? – гэж Теоден асуув.

- Харсаан эзэнтээн, Мөнгөн морьтой цагаан өвгөн энд тэндгүй л давхиад байна лээ. Саруман байх гэж хүмүүс бодсон гэсэн. Тэр харанхуй дундуур Изенгард руу давхисан гэж ярьцгааж байна. Бас Өмхий Амтыг харсан гэж ярьцгааж байна, тэр арай түрүүнд бөөн орх дагуулаад хойт зүг рүү явсан гэж байна.

- Гэндальфтай тааралдвал Өмхий Амтад атаархахгүй л юм байна, гэвч миний тэнэг гэдэг нь. Шинэ, хуучин хоёр зөвлөх хоёулаа зугтаачихлаа. Гэндальф явахдаа ганц хоёр юм хэлсэн л дээ. Ямар ч байсан Хельмагийн хавцалд хүрэх хэрэгтэй. Дайсны бөөн хүч ирж байна гэв үү? Ямаршуу хүч байна, танив уу?

- Замбараагүй олон дайсан, айсан нүдэнд дайсан олон гэдэг үг бий, гэхдээ би туршлагатай, зүрх зоригтой дайчидтай явсан. Тэдний хэлснээр бол орхуудын толгойн сэргийлэх гэхэд л манай нийт хүчнээс олон дахин их.

- Тэгвэл яарцгаая, бидний болоод цайзын хооронд байгаа дээрэмчдийг эхнээс нь эцсийг нь хүртэл толгой дараалан хяргая. Хельмагийн цайзын цаадах агуйнуудыг мартаагүй биз? Тэнд хэдэн зуун дайчин цугларсан байх ёстой, тэндээс уул руу нууц гарц байгаа.

- Нууц гарцанд найдвар бага, Саруман тэдгээрийг аль хэдийн шиншилсэн байгаа. Гэхдээ цайзыг удаан хамгаалж болно. Урагшаа!

Арагорн, Леголас хоёр Эомертой зэрэгцэн дайчдын манлайд давхиж явлаа. Харанхуй өтгөрч, зам дээш өгссөн тул морьдын алхаагаар өгсөв. Зам чөлөөтэй болж, орхууд халз тулгарахаас айж, хоромхон зуурт бутран алга болжээ.

- Эзэн захирагч цэргээ аваад ирж байгаа тухай Саруманд аль хэдийн ховлочихсон гэхээс айж байна, тэгээд ч манай цэргийн тоо дайсанд илэрхий - гэж Эомер баргар царайлан өгүүлэв.

Тэдний араас асар их нүргээн улам чангаран гүйцэж байв. Харанхуйг олон мянган хоолойн сөөнгө орилоон дүүргэлээ. Тэд өндөрт гарч ирээд эргэж харахад тоо томшгүй олон бамбар уулын бэлийг нэлд нь бүрхэн улаавгар галан хивс дэвссэн мэт харагдав. Бамбарын урсгал хажуу өөд урсан дээшилсээр байлаа.

- Бидний араас шороо шиг олон дайсан өсгий даран нэхэж байна – гэж Арагорн хэлэв.

- Тэд гал авч явна, замдаа тааралдсан бүгдийг галдана. Байшин барилга, ой шугуй, өвс бэлчээр. Баян хязгаар, дээдсийн адист тал хөндий, суурингууд. Надад, миний ард түмэнд их гай ирлээ дээ!

- Өдрийн гэрэлд сэн бол жолоогоо эргүүлээд галдан шатаагчдын дээрээс буух сан. Тэднээс зугтах гэдэг миний зан биш - гэж Арагорн байж ядна.

- Одоо зугтах газар бага үлдсэн. Хельмагийн Гати одоохон хүрнэ. Тэнд гүн суваг бий, найдвартай хамгаалалт болно, цайз хүртэл элбэг нэг бээр үлдсэн, эргээд л үзүүлээд өгнө - гэж Эомер түүнийг тайвшруулав.

- Үгүй ээ, Гатийг хамгаалах хүч бидэнд хүрэлцэхгүй, нэг бээрээс ч урт, маш өргөн шүү дээ - гэж Теоден болгоомжлов.

- Орох замаа тэртэй тэргүй хамгаалах хэрэгтэй, тэгэхээр ардаа хүч үлдээх хэрэгтэй - гэж Эомер хэлэв.

Морьт дайчдын эхний цуваа Горнбургаас Гати руу буусан өргөн зам дээр хүрэхэд саргүй тэнгэрт нэг ч од үзэгдэхгүй байв. Бүдэгхэн харлах ханын ангалаас харуулын дуу гарав.

- Ристаниин эзэн захирагч цэргээ удирдан Хельмагийн цайзад авчирлаа. Би Эомундын хүү Эомер ярьж байна.

- Бид та нарыг ирнэ гэж ёстой найдсангүй шүү, хурдан орцгоо! Тэгэхгүй бол орхууд дайраад орж ирнэ шүү.

Төдөлгүй тэд Гатийн цаана, голын эрэг дээрх налуу хажууд жагсав. Сэтгэл сэргэж, Эркенбранд цайзад хангалттай хүч үлдээсэн, тэднийг цөөнгүй дүрвэгсэд хүч нэмэгдүүлсэн тухай мэдээ амнаас аманд дамжууллаа.

- Бид мянга орчим явган дайчид болно, олон над шиг өвгөн бий, бас миний ач хүү шиг уруул дээрх сүү нь хатаагүй дайчид ч бий. Эркенбрандын талаар юу дуулдана? Өчигдөр түүнийг Вестфольдын сонгомол бүлэгтэй нааш ирж явна гэж дуулдсан. Өнөөдөр огт чимээ байдаггүй

– гэж харуулын ахлагч Гамлинг хэлэв.

- Манай тагнуулчид түүний талаар ямар ч мэдээгүй эргэж ирсэн, Хөндийгөөр дүүрэн дайсан буцалж байна. Тэр хаана байхав дээ гэж айж байна – гэж Эомер хэлэв.

- Тэр амь үрэгдсэн бол бидэнд их гарз даа. Хүчирхэг баатар ван, жинхэнэ Хельма Аяндын баатар зориг цогцолсон жанжин даа. Гэвч бид түүнийг энд хүлээж чадахгүй. Бүх хүчээ Горнбург руу татах хэрэгтэй байна. Та нар нөөцөөр хэр байна? Бид их хөнгөн яваа шүү дээ, хориглох гэж гараагүй, дайран байлдахаар гарсан.

- Вестфольдчуудын дөрөвний гурав нь энэ агуйнуудад хоргодож байна. Хөгшин залуу, хүүхэд эмэгтэйчүүд гээд бүгдээрээ. Гэвч нөөц удаан хугацаанд хүрэлцэнэ. Бүх малаа энд туугаад оруулчихсан, өвс тэжээл ч хангалттай бэлтгэсэн - гэж Гамлинг хариулав.

- Энэ чинь их сайн хэрэг, дайснууд хөндийг нэлд нь хуйхалж, юу ч үгүй болтол дээрэмдсэн.

- Хельмагийн цайзыг дээрэмдэхэд мөн ч амаргүй дээ, тэд дэндүү их үнэ төлөх байлгүй.

Цайзын гаднах далан дээр дайчид мориноосоо бууж, дараа нь эгц хажуугаар морьдоо хөтлөн Горнбургийн хаалгаар оров. Тэнд ч тэднийг баяр хөөр болон угтаж, цайзын хамгаалагчдын хүч ямар ч гэсэн хоёр дахин нэмэгдсэн болохоор шинэ найдвар төрж байлаа. Эомер даруй тушаал өгч, эзэн захирагчийг хамгаалагчид болон вестфольдын нэг зууттай Горнбургийг хамгаалахаар үлдээж, бусад бүх хүчийг Хавцлын хана болон өмнөд цамхагт байрлуулав. Тэнд тоолшгүй олон улайрсан дайсны хамгийн хүнд цохилт ирэх байлаа. Тэнд хамгийн аюултай тул өөрөө хамгаалалтыг удирдав. Морьдоо цөөн тооны хамгаалагчтайгаар хавцлын гүн рүү явууллаа.

Хавцлын хана өндрөөрөө хорин фут, дээгүүр нь дөрвөн хүн хөтлөлцөөд явж болох зузаан, шагайвч нь дайчдыг бүрэн хааж байв. Хана өөд гадаад ханын хаалганаас өгсч гарахаас гадна хавцлын талаас арын гурван шатаар өгсч гарах ажээ. Өмнө тал нь гөлийтөл өнгөлсөн, асар том чулуунуудыг тэгшхэн нийлүүлэн барьсан тул дээрээс тэнгисийн дээрх хясаа мэт өнгийж байв.

Гимли шагайвч налан зогсоод, Леголас ханын ирмэг дээр сууж, нумынхаа хөвчийг илэн, харанхуй руу харж байна.

- Энэ ч харин өөр хэрэг шүү, ууланд амьсгалах ч сайхан байдаг юм. Сайхан хясаанууд байна даа! Ер нь энэ хязгаар бөх хавиргатай юм байна. Мориноос буунгуут л хөл маань баярлаж байгаа гэж жигтэйхэн. Надад нэг зуун саданг минь өгвөл ямар ч дайсан наашаа шагайхгүй, шагайдаг юм бол ясаа цуглуулж дийлэхгүй дээ.

- Дуртай итгэж байна, чи бол жинхэнэ гном, бүхний гайхлыг төрүүлсэн гном, уулын хөдөлмөрийг шүтэгч. Харин надад энэ хязгаарын шөнө таалагдахгүй байна, өдөр ч ялгаагүй биз дээ. Гэхдээ чамтай хамт байхад өөртөө итгэлтэй байна, дэргэд минь ийм бүдүүн хөлтэй, бахим чийрэг дайчин байгаа нь сайхан. Үнэхээр чиний зуун садан чинь энд байвал илүүдэхгүй л юм байна. Бас Бөглүүд ойн зуун харваач байвал бүр ч сайн байхсан.

Ристаничууд сайн харвадаг ч гэсэн цөөн харваачтай юм даа. Тоотой хэдэн харваач!

- Харвахад харанхуй байна шүү дээ, харин сайхан унтаж авах юм биш үү. Над шиг нойрмог гном дэлхий дээр байхгүй шүү. Мориор аялна гэдэг чинь хэцүү юм байна. Харин сүх минь гарт тонгочоод л байна. За яахав, унтаж болдоггүй юм бол нааш нь ахиухан орх оруулчихна биш, сүх далайх зай л байвал болох нь тэр, юун нойр хүрэхтэй манатай юм болно.

Цаг тун удаан урагшилж байлаа. Хөндийн алсад түймэр шатаад дуусч байна. Изенгардын цэрэг одоо чимээгүй урагшилж, галт могой уул өөд мушгиралдан өгссөөр.

Гатийн зүгээс гэнэт чанга хашгирах, ристаничуудын хариу дохио сонсогдов. Хаалганы дэргэд бамбаруудын гэрэл цог мэт улалзан бөөгнөрснөө тарлаа. Арын хамгаалалтын дайчид голын нуга, хадархаг налуугаар Горнбургийн хаалган дээр хохиролгүй давхилдан иржээ.

- Тэд суваг руу дайрч байна. Бид бүх сумаа харвачихаад ирлээ. Суваг дайсны хүүрээр дүүрсэн. Тэд удаан саатахгүй, тал талаас л дайраад байна, тоо томшгүй олон, шоргоолж шиг л язганаж байна. Гэвч цайз руу бамбар барьж дайраад тэдэнд сайн юм болохгүй л дээ – гэж тэд ярив.

Шөнө дунд өнгөрлөө. Тас харанхуй, бүгчим нам гүм аянга цахилгааныг зөгнөн байв. Гэнэт нүд гялбам цахилгаан үүлсийг ташуурдан, зүүн оргил дээгүүр аварга том салбарласан аянга гялсхийн нүргэлэв. Цайзын хананаас Гати хүртэл гэрэл цахилж, тэнд хар цэргүүд өт шиг язганаж харагдав. Өргөн бөгст тагжгар орхууд, өндөр сүрлэг, хар бамбайтай орхууд тод харагдав. Гатийн цаанаас шинэ шинэ зуутууд завсаргүй үерлэн зүтгэж байна. Аянгын дуу хөндийг доргиолоо. Аадар бороо асгарав.

Харин цайзын ханан дээр өөр, үхэл тээгч бороо асгарлаа. Сумнууд нүүгэлтэн нисч ирээд хананд тусч, арагш ойн доош унаж, зарим нь хэрэм давж байлаа. Хельмагийн цайзыг ийнхүү дайрч эхлэв. Харин цайзын хамгаалагчид нам гүм, нэг ч сум тавилгүй хүлээж байв.

Нам гүм, заналхийлсэн чулуун аюул руу зүрхлэн дайрч чадахгүй арагшаа чихэлдэн түрж байсан орхууд дараалсан хэдэн аянга нижигнэсний дараа зориг орж, байдгаараа орилолдон жад, сэлмээрээ даллаж, хэрмийн орой руу суман мөндөр буулгана. Ристаничууд сүйрлийн аюулт хар давалгаа руу гайхан харцгаана. Зэс бүрээ цуурайлахад Саруманы хар арми цайз өөд уухайлан дайрлаа. Нэг хэсэг нь Хавцлын хана болон өмнөд цамхаг руу, нөгөө хэсэг нь далан давж, ирмэг дээгүүр гүйн гараад Горнбургийн хаалга руу дайрав. Тийшээ хамгийн том орхууд, Дунландын уулын галзуучууд довтолж байна. Аянга цахилгааны гялбаанд тэдний дуулга, бамбай дээр цагаан даль тод үзэгдэнэ.

Цайз гэнэт сэрсэн юм шиг тэднийг суман үүл, чулуун мөндөрөөр угтав. Хар давалгаа цочин самгардаж арагш замбараагүй ухран хүч алдсанаа дахин урагш дайрч, дахиад ухарч, дахин дайрсаар байв. Бүрээнүүд нь түрүүчийнхээсээ чанга хангинахад дунландчууд толгой дээрээ том том бамбайнуудаа барьж, урт жаднуудаа сунган хоолойн чадлаараа бархиран дайрав. Тэдний зарим нь төмрөөр бүрсэн хоёр нүсэр том гуалин өргөн гүйлдэнэ. Тэдний ард орх харваачид шавааралдан шуурган сум нүүлгэнэ. Энэ удаа гуалин хаалганд хүрч, нүсэр хүнд цохилтоос нь хаалга ганхлаа. Хэрмэн дээрээс чулуун мөндөр буусаар байвч, унасан нэгийн оронд тэр даруй хоёр дайсан халааг нь авч байв. Гуалин таранууд цайзын хаалгыг улам ч

хүчтэй балбаж эхлэв.

Эомер, Арагорн хоёр хэрэм дээр зэрэгцэн зогсч байлаа. Тэд дайснуудын дайчин уриа, тарануудын бөглүү цохилтыг сонсч байсан бөгөөд цахилгаан дахин нэгэнтээ гялсхийхэд хаалга хариугүй нээгдэх гэж байгааг хоёулаа ойлгов.

- Түргэлээрэй! Илдээ сугалах цаг боллоо – гэж Арагорн хашгиран ухасхийв. Хоёр дайчин салхи мэт хурдлан дээш гараад арван хамгийн гарамгай цавчигчийг дагуулан шатаар доошлон Горнбургийн гадна гараад ханан дахь нууц хаалгаар дамжин, нарийхан замаар хаалга руу гүйж хүрлээ. Эомер, Арагорн хоёр түрүүлж, дайчид араас нь арайхийн гүйцэж байв. Хоёр илд зэрэгцэн гялалзлаа:

- Гутвинэ! Гутвинэ и Мустангрим! – хэмээн Эомер уухайлж Арагорн:

- Андрил! Андрил и Дунадан! – хэмээн уухай хадаана.

Дайснууд хажуу талаасаа довтолно гэж бодоогүй, довтлогчдын цавчилт аймшигтай, цагаан дөл цацруулан гялалзах Андрил дайснуудыг бараг бөөн бөөнөөр нь хяргаж байв. Хэрэм, цамхаг дээрээс:

- Андрил! Андрил бидний төлөө тулалдаж байна! Хугарсан илд дахин амилжээ! – хэмээн баяртайгаар түрхрэлдэн хашгирна.

Уулынхан таранаа хаяад тулалдахаар ухасхийсэн боловч тэдний бамбайнууд илжирсэн самрын яс шиг хэм үсэрлээ. Цавчигдсан дайснууд үхэдхийн унацгааж, хясаан дээрээс хийсч, орх харваачид онилолгүй ганц нэг сум тавиад ум хумгүй зугтацгаав.

Эомер, Арагорн хоёр хаалганы дэргэд нэлээд саатав. Алсад аянга хүржигнэж, хаа нэгтээ өмнөд уулсын дээгүүр цахилгаан цахилна. Умар зүгээс дахин салхилав. Уранхай үүлс тарж бутран, тэнгэрт одод анивчиж, бүдэг шаргал сар гэрэлтэв.

- Бид амжиж ирсэн байна – хэмээн Арагорн хаалгыг ажиглаад хэлэв. Хаалганы бат бөх түгжээ болон төмөр хөндлөвч нь тахийжээ. Асар зузаан самбар нь ан цав гарсан байв.

- Гэвч бид энд гаднаас нь хамгаалж дөнгөхгүй, хараач - гээд Эомер дайсны зүг заавал орхууд болон дунландчууд дахин дайрахаар бөөгнөрч байв. Сумнууд нисэн ирж хад чулуунд тусч байлаа.

- Явцгаая! Хаалгыг дотор талаас нь чулуугаар овоолж, гуалингаар дарах хэрэгтэй. Яаралгүй болохгүй!

Тэр хоёр буцан гүйлээ. Энэ үед алагдагсдын дунд хэвтэж байсан арваад орх босч, тэр хоёрын араас гүйлдэв. Тэдний хоёр нь маш хурдан, чимээгүй гүйж, хоцорсхийж явсан Эомерыг хэдхэн харайгаад гүйцлээ. Гүйцэнгүүт дэгээдэж унагаад дээр нь унаж, сэлмээ шүүрэв. Харанхуйгаас гэнэт хэнд ч харагдаагүй байсан намхан хар дүрс сөөнгөө хоолойгоор: “Барук Казад! Барук ай-мену!” хэмээн уухайлаад хоёр удаа сүх гялсхийхэд толгойгүй хоёр орх

түсхийн унав. Бусад нь тарж зугтлаа. Арагорн ардаа юу болж байгааг нуруугаараа мэдэрч эргэж харахад Эомер босчихсон байлаа. Хананы нууц хаалгыг сайтар түгжээд, цайзын хаалгыг чулуу модоор овоолон бэхлэв. Тэгээд Эомер самбаачлан аврагчдаа хандав:

- Баярлалаа чамд, Глоины хүү Гимли! Чамайг бидэнтэй гадагш гарсан гэж би мэдээгүй. Урилгагүй зочин хамгийн чухал зочин болдог явдал бий. Чи яах гэж гарсан юм бэ?

- Жаахан зугаалж, нойроо сэргээх гэсэн юм. Тэгээд харсан чинь тэр уулынхан чинь айхтар том биетэй, тэнхээтэй юм байна. Тэгэхээр нь чулуун дээр суугаад та нар илдээр яаж ажиллаж байгааг чинь шохоорхсон юм.

- Одоо би чамд төлж барахгүй өртэй боллоо.

- Шөнө урт, төлж амжина – гээд Гном инээв: - За энэ дэмий яриа яахав. Гол нь ажлаа эхэллээ, тэгэхгүй бол би бүр Мориугоос нааш сүхээрээ мөчир л цавчиж явлаа шүү дээ.

- Хоёр! - гэж Гимли сүхээ илэнгээ бахтай хэлээд хана руу эргэж очлоо.

- Бүхэл бүтэн хоёр уу? - гэж Леголас шоолонгуй асуугаад: - Минийх арай олон юм аа, гэвч сум түүх хэрэгтэй болсныг харж байна уу. Саадганд маань нэг ч сум алга. Хорийг бол найдвартай хэвтүүлсэн, тэгээд ямар хэрэг байна? Тэднийг чинь алж барах нь бүү хэл тоолж барахгүй олон юм.

Тэнгэр цэлмэж, жаргаж байгаа сар тод гийлээ. Гэвч сарны гэрэл тэднийг баярлуулсангүй, дайсны цэрэг харсаар байтал үй түмээр нэмэгдсээр байв. Төдөлгүй тэд хаалга руу хоёр дахин их хүчээр дайрлаа. Галзуу хар хүчин хана өөд авирч, Горнбургээс өмнөд хаалга хүртэл хэрмийн ханыг хар ялаа шиг бүчив. Төмөр дэгээтэй бугуйл хэрэм даван ирж, хананд шигдэн, ристаничууд тэрийг нь тас цавчиж, мулталж амжихгүй болов. Хэдэн зуун шаг авчирч, хэрэм дээрээс шидэгдсэн орхуудын оронд хоёр дахин олноор гарч ирж байв. Орхууд шатан дээрээс хэрмийн оройд хэрэм мэт дүүлэн гарч ирж байлаа. Хэрмийн ёроолд дайсны хүүр овоорч, махчин орхууд, улайрсан хүмүүс овоолоостой үхдлүүд дээгүүрээ авиран төгсгөлгүй цувсаар байв.

Ристаничууд сүүлчийн хүчээ шавхан тулалдсаар байлаа. Тэдний саадаг хоосорч, жад нь хугарч, илдний ир нь эмтэрч, бамбай нь цуурсаар. Арагорн, Эомер хоёр дайчдыг удирдан гурван удаа гадагш гарч, гурван удаа дайсныг ухраав.

Дайснууд хавцал доогуур ар талд гарчээ. Орхууд ханан доогуурх усны хонгилоор дамжин хавцалд нуугдаад бүх дайчид ээлжит дайралтыг няцаахаар дээш гарах үед бөөн бөөнөөрөө хавцлын гүн рүү ухасхийж, бараг хамгаалалтгүй орхисон морьдыг тарааж хөөжээ.

Гимли ханан дээрээс гадна хашаа руу харайн буугаад “Казад! Казад!” - хэмээн дайчин уриагаа хавцал дүүрэн хадааж, шууд ажлаа эхлэв.

- Э-гой! Орхууд араас дайрлаа! Эгей! Нааш ир, Леголас! Энд бид хоёрт хангалттай хүрэлцэхээр ажил байна! Казад ай-мену! – хэмээн тэр хашгирна. Өвгөн Гамлинг цайз

дээрээс гномын дууг тулааны нүргээнээс ялгаж сонсов.

- Орхууд хавцалд оржээ! Хельм! Хельм! Миний хойноос, Хельмагийн хөвгүүд ээ! – гэж өвгөн дайчин хашгираад, вестфольдчуудыг тэргүүлэн доош буулаа. Гэнэтийн дайралтад сандарсан орхууд мухар хавцалд хар хурдаараа харайж ороод, тэндээ толгой дараалан цавчуулж, хясаан дээрээс шидүүлэхийг нууц агуйнуудын харуулууд чимээгүй ажиглаж байлаа.

- Хорин нэг! – гэж Гимли сүхээ далайн сүүлчийн орхыг хөсөр унагаад, эрхэм найз Леголас минь, тоо тэнцлээ – гэж хашгирав.

- Энэ хархны нүхийг хаамаар байна, гномууд гайхамшигтай уран чулуучид гэж ярьдаг, бидэнд туслаач, ноёнтоон! – гэж Гамлинг гуйв.

- Сүхээрээ чулуу цавчихгүй, хумсаараа ч маажиж чадахгүй байх, гэхдээ оролдоод үзье – гэж Гимли хариулав.

Вестфольдчууд чулуу түүж, хайрга хамаад Гимлийн удирдлагаар усны цооногийг хааж, зөвхөн жижиг нүх үлдээв. Борооны дараа үерлэсэн Хавцлын гол хөөс цахруулан хавцал дундуур тонгочиж байлаа.

- Дээр хуурай байгаа байх, явцгаая Гамлинг, ханан дээр юу болж байгааг харцгаая.

Леголас Арагорн, Эомер хоёрын дэргэд зогсоод урт кинжаалаа хурцалж байна. Усны цооногийг хаасан нь дайснуудыг сандаргасан бололтой, дайралт түр намжжээ.

- Хорин нэг! – гэж Гимли зарлав.

- Онцсайн! - гэж Леголас хэлээд: - Гэхдээ миний тоо хоёр арваар нэмэгдсэн. Энд кинжаалаараа л ажиллалаа даа - гэв. Эомер, Арагорн хоёр ихэд ядарсан шинжтэй илдээ тулан зогсоно. Цайзын зүүн талд дахиад тулалдааны чимээ нижигнэлээ. Гэвч Горнбург давалгаат тэнгис доторх хадан цохио шиг хөдөлбөргүй зогссоор л байв. Хаалга нь эвдэрсэн боловч чулуу, гуалин овоог нэг ч дайсан давж ирсэнгүй.

Арагорн бүдэгхэн анивалзах одод, жаргаж буй сарыг хараад:

- Энэ шөнө чинь олон жилийн хорио шиг урт байх чинь. Өдөр яагаад удаад байна аа?

- Удахгүй өглөө болно - гэж Гамлинг Гимлийн араас гарч ирээд: - Өдөр боллоо гээд ямар ялгаа байхав, биднийг бүслэлтээс гаргаад өгөх юм биш.

- Үүрийн гэгээ аль эртнээс хүмүүст итгэл найдвар өгч ирсэн юм

- Энэ Изенгардын бузрууд, хагас орх, хагас хүмүүс, Саруманы хар шидээр бүтсэн юмнуудад нар ямар ч хоргүй, уулынхан ч гэрлээс айдаггүй. Тэд яаж байлдаж, орилолдож байгааг сонсч байгаа биз дээ?

- Сонсох нь ч сонсч байна, харин тэдний орилоон хүнийхтэй адилгүй, араатантай ч адилгүй,

шувууныхтай л төстэй юм – гэж Эомер хэлэв.

- Хэрэв сонсох юм бол үгийг нь ялгана шүү. Дунланд хэл байна, би залуугаасаа сонсч байсан юм. Нэгэн цагт энэ хэл Ристаниин баруун нутагт газар сайгүй сонсогддог байсан юм. Сонсч байна уу? Тэд биднийг яаж үзэн ядаж, бидний энэ бэрх цагт яаж баярлаж хөөрч байгааг нь! “Эзэн захирагч, танай Эзэн захирагч хаана байна? Тэрнийгээ бидэнд гаргаад ир! Форгойлуудад үхэл, шар үст үхдлүүд сөнөтүгэй! Умардын дээрэмчдэд үхэл!” ингэж л биднийг хүндэлж байна даа. Бидний эзэн дээдэс Эорл Гондорын холбоотон, энэ хязгаарын эзэн болсонд тэд таван зуун жил хорсч байгаа юм. Хар Саруман тэр хорслыг нь улам дэвэргэсэн, одоо эд зогсохгүй. Тэдэнд харанхуй, гэрэл гэгээ ч хамаагүй. Теоденийг тамлуулахаар өг, тэгээд л гүйцээ!

- Гэлээ ч гэсэн гэрэл гэгээ бол найдварын зарч. Горнбург нэг ч удаа дайсанд эзлэгдэж байгаагүй, түүнд хамгаалагчид байгаа цагт хэзээ ч эзлэгдэхгүй гэдэг үнэн үү? – гэж Арагорн хэлэв.

- Дуунд л тэгж дуулдаг юм – гэж Эомер ядрангуй хариулав.

- Тэгвэл нэр төртэй хамгаалагчид нь байцгаая! - гэж Арагорн хэллээ.

Тэдний яриаг бүрэн дуу таслав. Нүргэлсэн их чимээ нижигнэж, гал дүрэлзэн, өтгөн утаа бүрхлээ. Хавцлын гол шуугин оволзож, хөө цацруулсаар голдрилоо сольж, хэрмийн хананд гарсан том нүхээр орж ирэв. Тэндээс хар цэргүүд цутган орж ирлээ.

- Хараалт хар Саруман! - гэж Арагорн хашгираад: - Биднийг энд ам хэлээ билүүдэж байх хойгуур орхууд дахиад усны цооногоор орж, ханыг Ортханкийн хар шидийн галаар дэлбэлжээ! Элендил, Элендил! – хэмээн хашгираад тэр хананд гарсан нүх рүү харайлгав. Тэр хооронд орхууд шатаар хэдэн зуугаараа авиран гарч ирлээ. Ар талаас бас зуу зуун дайсан авиран гарч, энд тэндгүй тулалдаан оволзов. Хамгаалагчид сөөм газар бүрийн төлөө тулалдан агуйнууд руу ухарч, зарим нь цайз руу дайсны бөөн хүчийг сэт дайран гарлаа..

Хавцлаас өргөн шат цайзын хана руу, Горнбургийн арын хаалга руу хөтөлсөн байв. Арагорн шатны дор дөл бадарсан илдээ барин зогсчээ. Орхууд түүнээс айн ухарч, шатанд хүрч амжсан Ристанийн дайчид дээшээ ум хумгүй гүйлдэж байв. Леголас Арагорноос хэдэн гишгүүр зайтай нэг өвдөг дээрээ суугаад нумаа онилон зориглон хөдөлсөн орхыг нам харвахаар зэхжээ.

- Гүйцээ, Арагорн, хар дээрэмчид мухарт хаагдлаа! Хаалга руу явцгаая – гэж тэр хашгирав.

Арагорн түүний араас гүйсэн боловч ядарч цуцсан хөл нь бүдрэв. Тэгмэгц отожд байсан орхууд баярлан орилолдсоор ухасхийлээ. Түрүүчийнх нь Леголасын сумыг хоолойдоо зоолгон унахад бусад нь дээгүүр нь харайн дайрав. Гэтэл дээрээс онож унагаасан том хад тэднийг хавцал руу хийсгэлээ. Хаалга Арагорны араас чихран хаагдав.

- Бидний ажил ч тааруухан боллоо доо, андууд минь – гээд тэр духны хөлсөө шудран арчив.

- Энэнээс муу юм ч гэж байхгүй л байх аа даа, гэвч чи амьд мэнд байгаа чинь сайн хэрэг, Гимли хаа байна – гэж Леголас хэлэв.

- Бүү мэд, тэр ханын дэргэд цавчиж явахыг би харсан, дараа нь бид тал тал тийшээ салсан.

- Ой-ой-ой! Ийм мэдээ байх гэж!

- Зүгээр дээ, тэр чийрэг, хүчирхэг дайчин. Агуй руу яваад хүрчихсэн гэж найдъя, тэнд бидний эндээс хамаагүй дээр. Гном ямар ч агуйд гэртээ байснаас дээр байдаг юм.

- За, тэгж л найдахаас даа, гэвч наашаа цавчаад ирсэн бол сайн байсан юм. Миний тоо гучин ес хүрснийг мэдэх байлаа.

- Хэрэв тэр агуйд хүрсэн бол чамаас дахиад л тоогоор илүү гарна – гээд Арагорн инээж: - Сүхээ тэр хайр хүрмээр гоё эзэмшдэг юм билээ.

- Явж сум хайя, энд тэнд бүтэн сум хэвтэж байж магадгүй, өглөө хэрэг болно.

Арагорн дээшээ цайзад ороод Эомер Горнбургт байхгүй байгааг мэдэв.

- Эрсний хэрэггүй, тэр ирээгүй, хавцлын салаа аман дээр дайчдыг цуглуулаад тулалдаж байхыг нь би харсан. Түүнтэй хамт Гамлинг, гном хоёр тулалдаж байсан, гэхдээ тийшээ очих аргагүй байсан юм – гэж хамгаалагчдын нэг нь хэлэв.

Арагорн дотоод талбайгаар гарч, цамхаг дээр гарахад эзэн захирагч нарийхан цонхны дэргэд бөгтийн зогсч байлаа.

- Шинэ юм юу байна, Арагорн? – гэж тэр асуув.

- Хавцлын хана эзлэгдсэн, Цайзын хамгаалалт цохигдсон, гэвч олон хүн Горнбургт нэвтрэх амжсан эзэнтэн минь.

- Эомер энд байна уу?

- Үгүй ээ эзэнтээн. Гэхдээ хавцалд цөөнгүй дайчин ухарч хориглосон. Тэдний дотор Эомер байсан гэж ярьж байна. Магадгүй, тэнд давчуу учир дайсныг тогтоогоод, агуйнуудад хүрсэн байж боллох юм. Харин цаашдаа тэд яадаг юм бол доо...

- Тэдэнд цаашдаа яах нь тодорхой. Нөөц хангалттай бий. Агаар сайтай, таазанд нь агааржуулах цонх байгаа. Агуйнуудад амнаас нь өөр нэвтрэх аргагүй. Эцсээ хүртэл хамгаалах л хэрэгтэй. Нэг үгээр хэлэхэд удаан тэсч чадна.

- Тэр ч тийм л байдаг байж, гэвч орхуудыг Ортханк хана нэвтрэх галаар зэвсэглэсэн байна. Тиймгүй сэн бол бид хэрмийг тэдэнд алдахгүй байсан. Дайсан агуйнуудад хүрэх юм бол амыг нь дэлбэлээд бөглөж чадна. Ингэхэд одоо бид тэдний тухай биш, өөрсдийнхөө тухай бодох хэрэгтэй байна.

- Энд надад нүхэнд байгаа юм шиг бүгчим байна. Цэргийнхээ өмнө морин дээрээ, жадаа бариад явж байгаа бол ядаж тулалдааны шуналыг сүүлчийн удаа мэдрэх сэн. Энд миний хэрэг гэж юу байхав дээ.

- Юуг ч харахан алдаагүй байна. Одоохондоо чи амьд мэнд, Ристанийн нэвтэршгүй цайзад цэрэгтэйгээ байна. Бидэнд Эдорос, бүр Дунхэргээс ч илүүгээр Горнбургийг хамгаалах найдвар байна.

- Тийм ээ, Горнбург өнөө болтол дайсны гарт нэг ч орж үзээгүйгээрээ алдартай. Гэхдээ энэ удаа би үүнд итгэлгүй байна. Олон зууныг үзсэн бат цайзууд үнсэн товрог болж байна. Тэгээд ч ийм их хүчний галзуу дайралтад ямар цайз тэсэх билээ! Изенгардын хүч ингэж их өссөнийг мэдсэн бол би Гэндалфыг үг дуугарангуут үгэнд нь орж, хүчээ үзэх гэж ийм бодлогогүй алхам хийхгүй байсан. Одоо бол тэрний зөвлөгөө, ятгалга, өглөөний наран доорхоос өөр үнэтэй.

- Эзэнтэн минь, Гэндалфын зөвлөгөөг цагаас эрт бүү шүү.

- Юуг нь хүлээх юм бэ? – гэж Теоден гашуунаар хэлээд: - Бидний төгсгөл ойрхон бөгөөд гарцаагүй байна, гэхдээ би нүхэндээ утуулсан дорго шиг үхэхийг хүсэхгүй. Цагаан дэлт, Хазуфел болоод миний хамгаалалтын бусад морьд энд, дотоод хэрэмд байгаа. Үүрээр би Хельмагийн бүрээг үлээхийг тушааж, бүслэлтийг сэтлэхээр дайрна. Чи надтай хамт явах уу Араторны хүү? Бид бүслэлтийг сэтлээд гарч магадгүй, чадахгүй бол тулалдаанд амь үрэгдэж, зохиох хүн амьд үлдвэл дуунд дуулагдана биз.

- Би чамтай хамт явна аа – гэж Арагорн хэлэв.

Тэгээд гадаад хэрэмд эргэн ирж, дайчдын сэтгэлийг сэргээн тэдэнтэй хамт хамгийн аймшигтай довтолгоог ч няцаасаар байлаа. Леголас түүнээс алхам ч хоцорсонгүй. Дэлбэрэлт ар араасаа нүргэлж, хадан хана доргисоор. Хэрмийн дээгүүр дэгээ хаяж, эвхмэл шат тавин авирсаар. Дайснууд зуу зуугаараа хэрэм дээрээс шидэгдсээр байлаа. Горнбургийн цайз бат зогссон хэвээр.

Арагорн хаалганы дээрх нуман шагайвч дээр гарч ирэв. Эргэн тойронд дайсны сум исгэрнэ. Тэрбээр дорно зүг рүү харж, хаяанаасаа цайвартаж буй тэнгэр рүү хараад, хэлэлцээ хийх дохио өгч гараа алгаар нь дайсан руу харуулан өргөв.

- Буугаад ир! Буугаад ир! – хэмээн орхууд баярлан хашгиралдаж: - Чамд хэлэх юм байгаа бол наашаа буугаад ир! Хулчгар эзэн захирагчаа бидэнд өг! Бид бол хүчирхэг дайчид, бид бол ялагдашгүй Урукхай! Тэртэй тэргүй бид тэрэнд хүрч, нүхнээс нь чирч гаргана. Эзэн захирагчаа өг!

- Цайзаас гарах байх аа эзэн захирагч өөрөө мэднэ – гэж Арагорн хэлэв.

- Чи яах гэж гарч ирсэн юм бэ? Чамд юу хэрэгтэй юм бэ? Биднийг тоолох нь уу? Бид бол Урукхай, бидэнд тоо байхгүй – хэмээн дайснууд даажигнав.

- Би үүрийн гэгээг угтахаар гарч ирсэн юм.

- Чиний тэр үүрийн гэгээ бидэнд ямар хамаа байна? – хэмээн доороос хөхрөлдөөд - Бид Урукхай, бид өдөр ч, шөнө ч тулалддаг, нар ч, аадар бороо ч бидэнд юу ч биш. Хэзээ алахад ямар ялгаа байна, нарны гэрэлд сарны туяанд ялгаагүй? Чиний үүрийн гэгээ бидэнд юу юм бэ?

- Шинэ өдөр юу авчирч байгааг хэн мэдэх юм бэ, амьд мэнд дээрээ эндээс тонилцгоо.

- Наанаасаа буугаад ир, тэгэхгүй бол харвалаа шүү! Энэ бол хэлэлцээ биш, чи зүгээр л цаг хожих гэж дэмий донгосч байна – хэмээн хариу хашгиралдав.

- Чихтэй болгон нь сонс, Горнбург хэзээ ч дайсныг нэвтрүүлж байгаагүй юм, одоо ч гэсэн оруулахгүй. Хурдан зугтаацгаа, тэгэхгүй бол өршөөл байхгүй шүү. Нэг чинь ч амьд үлдэхгүй, танай мэдээлэгч ч амьд үлдэхгүй. Та нарын сүүлчийн цаг цохиж байна!

Арагорн эвдэрхий хаалган дээрээс үй олон дайсан руу эгц харан ганцаараа зогсоод ийм итгэлтэй, захирангуй хэлэхэд олон уулынхан хөндий рүү айсан байртай эргэн харж, бусад нь тэнгэр рүү гайхан харж байв. Гэвч орхууд хорсолтой хөхрөлдөж, ханан дээгүүр үүл мэт сум нисэн өнгөрөхөд Арагорн золтой л харайчихсангүй.

Гэнэт чих дөжрөм нүргээн хадаж, гал утаа оволзов. Дөнгөж сая түүний зогсч байсан хаалганы бат бэх жааз доош сууж, гал утаан дунд үзэгдэхгүй болов. Хаалганы дотор овоолсон чулуу, гуалингууд сүрэл шиг хийсэн алга болов. Арагорн цамхаг өөд гүйлээ.

Орхууд баярлан орилолдож, хаалганы онгорхойгоор бөөнөөрөө дайран орох гэтэл тэртээ доороос нэгэн түгшүүртэй бөгөөд учир нь үл олдох битүү хүнгэнэсэн шуугиан сонсдов. Бүслэгчид дороо нам зогсч, ийш тийшээ харан чагнав. Тэгтэл цамхагийн орой дээрээс гэнэт Хельмагийн том бүрээ хүнгэнэн цуурайллаа.

Дайснуудын нуруу хүйт оргиж, дагжин чичрэв. Ихэнх нь чихээ бөглөн газарт хөсөр уналаа. Хавцал дүүрэн цуурай нижигнэж, хясаа болгон дээр бүрээчид зогсоод байлдааны уриа үлээж байгаа мэт үй олон бүрээн дуу цуурайллаа. Горнбургийн хамгаалагчид гайхах, баярлах зэрэгцэн дуугарч чадахгүй чагнан зогсч байлаа. Аянга мэт бүрээн дууг уулс залган авч эцэс төгсгөлгүй цуурайлан байв.

- Хельм! Хельм! – хэмээн ристаничууд дуу орон хашгиралдаж: - Хельм амилан босоод тулалдаанд орж байна! Хельм, Теоден!

Эзэн захирагч цасан цагаан морьтойгоо, алтан дуулга, асар том жадаа өргөсөөр гарч ирэв. Түүний дэргэд Элендилийн залгамжлагч Арагорн, түүний араас Эорлын баатар вангууд эгнэн гарч ирлээ. Үүр цайж харанхуй алга боллоо.

- Эорлын хөвгүүд урагшаа! – хэмээн морьт дайчид дайчин уриагаа нижигнэтэл хашгирч, зэр зэвсгээ яралзуулан Изенгардын газар харанхуйлсан их цэрэг рүү довтлон ороод хаалганаас далан хүртэл зүсэн давхихдаа дайснуудыг өвс сүрэл шиг цавчин хяргаж, морьдын хөлд

гишгэчүүлэв. Агуйнуудаас хуйлран гарсан дайчид уухай хадаан хар олон руу цавчилдан орлоо. Горнбургийн бүх хамгаалагчид тулалдаанд оржээ. Ууланд бүрээнүүд дуу дуугаа авалцан цуурайлсаар.

Аварга биет орхууд ч, уулын үлэмж биетнүүд ч эзэн захирагч болон түүний баатар вангуудын зуутын өмнө тэсч чадсангүй. Илднүүд толгойг нь тасар цавчиж, нуруу руу нь жад шигдэж байсан тул амьд үлдсэн нь орь дуу тавин эргэж ч харалгүй доош уруудан гүйлдэж байв. Учир нь тэд үүрийн гэгээ тусахад зэрлэг айдаст автан, зүүдэнд нь ч оромгүй гайхалтай юм болжээ. Эзэн захирагч Теоден Хельмагийн цайзаас ийн гарч Гатийг бүсэлсэн дайснуудыг үлдэн хөөв. Гати хүрээд дайчид зогслоо. Зүүн уулын цаанаас нар урган тэдний жадны үзүүрийг алтруулав. Дайчид мэл гайхан зогсч, хавцлын ам руу харлаа.

Тэндхийн газар танигдашгүй өөр болжээ. Урьд нь ногоон нуга үргэлжилж байсан бол одоо ер бусын дүнсгэр ой ургасан байв. Цайвар титэмт, аварга том нүцгэн модод эгнээ эгнээгээрээ зогсон, мөчир нь орооцолдож, өтгөн өвсөн дээгүүр бахим үндэснүүдээ дэлгэжээ. Моддын мөчир доогуур тас харанхуйлна. Гатигаас энэ ер бусын ойн зах хүртэл ердөө гурван зуун сажин зайтай байлаа. Тэнд Саруманы өмнөхөөсөө ч илүү аюултай шинэ арми бөөгнөрчээ. Тэднийг тэр дүнсгэр ой ристаничуудын илд жаднаас ч илүү айлгасан бололтой. Цайзаас Гати хүртэл амьд амьтан үгүй, харин доод бэлд газар харлан буцлах мэт үй олон дайсан бөөгнөрчээ. Баруун тийш эгц хадан хана өөд гарах зам байхгүй, харин зүүн талаас дайснуудын хувь заяа ойртож байлаа.

Тэнд, уулын орой дээр гэнэт гэрэл цацарсан цагаан хувцастай, цагаан морьтон гарч ирэв. Бүрээ хүнгэнэж, илдээ сугалсан явган дайчдын мянгат дайсан руу довтлон оров. Тэдний манлайд яваа улаан бамбайтай, хүчирхэг өндөр баатар ван том хар бүрээ үлээж довтлох дохио өгчээ.

- Эркенбранд! Эркенбранд! – хэмээн морьт дайчид дуу нийлүүлэн хашгирав.

- Хараач! Цагаан морьтон! Гэндальф туслах хүч аваад ирж! – гэж Арагорн хэлэв.

- Митрандир! Митрандир! - хэмээн Леголас залгаж аваад: - Энэ бол ид шид гэдгийг би ойлгож байна! Хурдлаарай, хурдлаарай, ид шид сарнихаас өмнө тэр ойг харъя!

Изенгардчууд хоёр их галын хооронд ийш тийшээ орилолдон хуйларна. Цамхаг дээрээс дахин бүрээ цуурайлахад эзэн захирагчийн морьт дайчид Хельма Гатийн гүүрээр уухайлан довтлов. Уулан дээрээс Вестьфольдын захирагч Эркенбрандын явган дайчид түрхрэн буулаа. Аянга уулын хажуугаар уулын буга мэт туурайгаараа газар шүргэхтэй үгүйтэй нисэн буув. Цагаан морьтноос айсан дайснууд ухаан алджээ. Уулынхан газар тэврэн хөсөр унаж, орхууд орь дуу тавин зэвсгээ хаяад өнхрөлдөнө. Тоолшгүй их цэрэг салхинд утаа замхрах мэт алга болов. Ухаан алдталаа айсан орхууд аврал эрэн моддын мөчир доогуур харанхуй руу гүйлдэн ороод тэндээ алга болцгоожээ.

Бүлэг 8

Изенгард хүрэх замд

Тийнхүү хаврын цэлмэг өглөө, Хавцлын голын дэргэдэх ногоон нугад эзэн захирагч Теоден, Цагаан морьт Гэндалф хоёр дахин уулзав. Тэдний дэргэд Араторны хүү Арагорн, эльф хан хүү Леголас, Вестфольдын захирагч Эркиенбранд болон алтан өргөөний түшмэд байлаа. Тэднийг тойрон ристаничууд, Мустангримын морьт дайчид хүрээлж, ялалтандаа баярлахаасаа илүү ид шидэд алмайран гайхаж, алга болоогүй байгаа нууцлаг ой руу дахин дахин харж байв.

Гэвч дайчид дахин баяртайгаар түрхрэлдэн шуугилдав. Гатийн цаанаас агуйгаас гарсан дайчид ирж явна. Хөгшин Гамлинг, Эомундын хүү Эомер, түүний дэргэд гном Гимли хоёр тийш найган алхаж явна. Түүний дуулга нь алга, толгойгоо боосон алчуур нь цус болсон ч дуу хоолой нь урьдын адил хөгжилтэй, чанга хэвээр байв:

- Дөчин хоёр, эрхэм найз Леголас минь! Харин сүүлчийнх нь ган захтай байсныг мэдсэнгүй. Тэрний толгой ниссэн боловч сүхний минь ирийг эмтэлчихлээ. Чиний тоо хэд вэ? – гэж тэр нэлээд холоос хашгирав.

- Чи надаас нэгээр түрүүлчихэж, за за, өөрөөрөө бахарх: Чи л хоёр хөл дээрээ найгаж байвал би хожигдсон ч гомдох юм алга! – гэж Леголас хариулав.

- Сайн явна уу, эгчийн хүү Эомер! чамайг амьд явааг харахад үнэхээр сайхан байна - гэж Теоден өгүүлэв.

- Сайн байна уу Ристаниин эзэн захирагч минь! Шөнийн харанхуй замарч, дахиад өдөр гийлээ. Гэвч энэ өглөө бидэнд ер бусын бэлэг авчирлаа! – гээд Эомер ой руу гайхан хараад, харцаа Гэндалф руу шилжүүлж: - Чи дахиад л бэрх цагт таагаа ч үгүй, мэдээ ч үгүй байхад хүрээд ирлээ.

- Таагаа ч үгүй, мэдээ ч үгүй гэв үү? Би уулзах газраа товлосон шиг санах юм.

- Гэхдээ чи уулзах цагаа товлоогүй, тэгээд бас чамайг юутай ирэхийг бид мэдээгүй, ийм ер бусын гайхалтай тусламж авчрахыг чинь таагаагүй. Чи үнэн агуу шидтэн байна, Цагаан Гэндалф!

- Магадгүй л юм. Гэхдээ энэ удаа миний ид шидгүйгээр болсон. Би зүгээр л цагийг нь олж, чухал зөвлөгөө өгсөн, Аянга намайг хөөдсөнгүй. Харин ялалтыг та нарын эрэлхэг зориг, вестфольдчуудын чийрэг хөл авчирсан. Тэд шөнийн турш нэг ч амралгүй явж ирсэн юм.

Бүгд Гэндалф руу мэл гайхан ширтэв. Нүдний булангаар ой руу харвал байж л байна. Бидний харж байгаа юмыг шидтэн харахгүй байна гэдэг хачин аа – хэмээн гайхацгаав.

Гэндалф хөгжилтэй инээж:

- Аа, та нар моднуудыг яриад байна уу? Би тэднийг та нараас муугүй харж байна. Гэвч тулалдааны үр дүн надаас шалтгаалаагүй. Энд Мэргэд бүгдээрээ цугларсан ч мэл гайхах байсан. Би үүнийг санаачлаагүй учир миний гавьяа гэж бодохгүй байна, гэхдээ ийм л юм боллоо.

- Чиний ид шид биш юм бол хэнийх юм бэ? Саруманых биш гэдэг нь ойлгомжтой. Тэгэхлээр та хоёроос илүү шидтэн хэн байдаг байна, мэдэх юмсан.

- Энэ бол ид шид, илбийн заль биш, энэ бол эртний их хүч сэргэсэн хэрэг, эд нар бол Дундад газрын хуучны эзэд. Энд эльфүүдийн дуу цангинахаас өмнө, алх төмөр дээр цохилохоос өмнө эд нар энэ газраар хэсүүчилж явсан юм – гэж Гэндальф өгүүлэв:

Хүдэр гэдгийг олборлоогүй байхад,

Хурц сүх моддыг шархлуулаагүй байхад,

Цагаан оргилт уулс цэл залуу асан,

Цагаргин бөгж байгаагүй өнө эрт үед

Цагт үл хавчигдан хэсч явсан юм эд нар.

- Чи оньсого таалгалаа, хариу нь хаа байна? - гэж Теоден асуув.

- Хариуг нь мэдэхийг хүсч байвал Изенгард руу надтай хамт яв.

- Изенгард гэнэ үү? – хэмээн бүгд зэрэг дуу алдав.

- Тийм ээ, Изенгард руу, миний зам тийшээ, хэн хүссэн нь надтай хамт явж болно. Биднийг тун ч хачин үзэгдэл хүлээж байгаа даа.

- Гэвч Ристани даяар хайгаад ч хангалттай олон дайчид олдохгүй. Бүгдээрээ эцэж цуцсанаа умартан, түрүүчийн шархаа тоолгүй толгой дараалан тулаанд мордсон ч Саруманы нэвгэршгүй бат цайзыг эзлэх байтугай бүслэхэд ч хангалтгүй шүү дээ – гэж Теоден хэлэв.

- Нэг үгээр хэлэхэд би Изенгард руу явна, надад цаг бага байна. Дорно зүгт харанхуй өтгөрч байна. Тэгэхлээр дараа сарын шинэдээр Эдорасетэд уулзъя!

- Үгүй ээ! Үүрийн өмнөх харанхуйд би чамд эргэлзэж байсан, харин одоо салахгүй. Хэрэв чи зөвлөж байгаа бол би чамтай хамт явна – гэж Теоден өгүүлэв.

- Би Сарумантай аль болохоор хурдан ярилцах хэрэгтэй байна. Тэр бидний хамаг гай зовлонгийн буруутан, та нар өөрсдөө шийд. Харин явбал одоо шууд явна, чадах уу?

- Дайчид маань байлдаанд туйлдсан. Би өөрөө ч гэсэн бүтэн хоног эмээл дээр давхиад, дараа нойргүй хоносон. Би өтөлсөн нь үнэн, Өмхий Амт өтөл насыг надад шивнээгүй. Энэ өвчнөөс салах аргагүй, Гэндальф ч салгаж чадахгүй.

- За яахав, тэгвэл надтай хамт явах нь одоо амарцгаа, орой хөдөлье. Тэр нь ч дээр, одоо миний зөвлөгөөг сонс. Нуугдаж явна, цөөхөн хүн авч явна. Байлдах гэж биш, хэлэлцээ хийх гэж явна.

Шархдаагүй дайчдаас цөөхөн элч томилж, хамгийн сайн морьдоо унуулан Ристани даяар тарааж довтолгов. Тэд ялалтын мэдээ тараахын хамт бүх эрчүүд зэвсгээ агсан хоёр хоногийн дараа дүүрэн сарнаар Эдораст хүрч байлдааны үзлэгт бэлэн байхыг тушаасан эзэн захирагчийн тушаалыг дамжуулахаар мордлоо. Эзэн захирагч Изенгард руу Эомер болон хорин дайчинг сонгож авлаа. Гэндальфтай хамт Арагорн, Леголас, Гимли нар мордох болов. Гном шархтай боловч андуудаасаа хоцрохыг хүссэнгүй.

- Шалбархай төдий юм аа, дуулган дээр хальт цохисон. Тэгээд ч шалбархай болгоныг шарх гэх юм бол...

- Одоо эмчлээдэхье - гэж Арагорн үгийг нь тасаллаа.

Теоден Горнбургт эргэж ирээд, олон жил унтаагүйгээрээ бөх гэгч унтав. Түүнтэй хамт алсын замд гарах дайчид ч унтлаа. Хүнд шархадсанаас бусад дайчид ажилдаа орлоо. Амь үрэгдсэн дайчдын шарилыг цуглуулан зохих ёсоор оршуулах хэрэгтэй байв.

Орхуудаас амьд үлдсэн нэг ч байхгүй боловч уулынхнаас маш олон нь амь гуйн олзлогдсон байлаа. Тэдний зэвсгийг хурааж ажилд нь оруулав. Дайсны хүүр тоолшгүй олон байлаа.

- Орхуудтай нийлж сүйтгэсэн бүхнээ бидэнтэй хамт сэргээн босго, Изений гармаар хэзээ ч дахин дайсагнах санаа өвөрлөж алхахгүй гэдгээ андгайл, тэгээд уул руугаа буцацгаа. Саруман та нарыг хуурсан, та нар түүнд итгэснийхээ төлөө их үнэ төллөө, хэрэв та нар ялсан бол бүр ч их үнэ төлөх байсан юм – гэж Эркенбранд тэдэнд хэлэв.

Дунландчууд чихэндээ итгэсэнгүй. Саруман тэдэнд хэрцгий ристаничууд олзлогдогсдыг амьдаар нь шатаадаг гэж үнэмшүүлсэн байжээ. Горнбургийн дэргэд хоёр том хиргисүүр босгож, нэгэнд нь вестфольдчуудыг, нөгөөд нь Эдорасын дайчдыг оршуулав. Цайзын ханын дэргэд Теодений гол хамгаалагч Гаймаг оршуулав. Тэрбээр хаалгыг хамгаалж байгаад амь үрэгдсэн байлаа.

Дайснуудын хүүрийг шинээр ургасан ойн дэргэд овоолуулав. Ийм их үхдлийг яах ёстойг хэн ч мэдэхгүй байсан учир олон хүн сандарчээ. Газарт булна гэхэд маш их ажил орно, тийм цаг хугацаа ч байхгүй, шатаана гэхэд түлэх мод хүрэхгүй, ер бусын ойд хэн ч гар хүрч зүрхлэхгүй билээ. Гэндальф тэр ойд ойртож ч болохгүй гэж хатуу сануулсан байв.

- Дайсны хүүртэй бүү ноцолд, маргааш өглөө гэхэд бүх асуудал шийдэгдсэн байна – гэж тэр хэлжээ.

Эзэн захирагч дагуулуудтайгаа замд гарах болоход оршуулгын ажил дуусаагүй л байв. Теоден үнэнч хамгаалагч Гаймаг хүндэтгэж түүний булшинд эхний атга шороог цацаад:

- Саруман надад болоод бидний эх оронд дэндүү их гай тарилаа. Би тэрэнтэй уулзахаараа

үүнийг сануулна – гэж амлав. Нар баруун уулс руу тонгойж байлаа. Теоден, Гэндальф нарыг Гаги хүртэл дайчид, вестфольдчууд, агуйнуудаас гарч ирсэн хөгшид, хүүхэд, эмэгтэйчүүд дагаж үдэв. Ялалтын дуу цуурайснаа гэнэт нам гүм болов. Дүнсгэр ой ристаничуудыг айлгажээ. Ойн захад очоод морьд нам зогсов. Тэд ч гэсэн ой руу орохыг хүсэхгүй байлаа. Хөдөлгөөнгүй саарал модод манантсан утаан дунд заналтай зогсч, мөчрүүд нь шүүрэн авах гэж байгаа сарвуу шиг сэрийлцэн, үндэснүүд нь махир тэмтрүүл мэт сарайж, доогуур нь гүн харанхуй харагдав. Гэвч Гэндальф урагш хөдлөхөд бусад нь дагаж, зам хаасан моддын хатангир хатуу мөчрүүдийн доогуур цувран ороход зам чөлөөтэй болж, хажуугаар Хавцлын гол шуугин урсч, тэнгэр нарны алтлаг туяагаар гийж байлаа. Хоёр талаар эгнэсэн модод харанхуйд бүрхэгдэж, алсаас чихран харжигнах чимээ, орилолдоон сонсогдож байв. Орхууд ч, ойн амьтад ч байсангүй.

Леголас, Гимли хоёр нэг моринд сундалдаад Гэндальфаас хоцролгүй дагаж явав. Гимли ойгоос маш их айж байлаа.

- Бүгчим байна шүү, биднийг догшин уур хилэн бүсэлсэн байна. Агаар тачигнаж байгааг сонсч байна уу? - гэж Леголас Гэндальфаас асуув.

- Сонсч байна аа.

- Хөөрхий орхууд яасан бол?

- Энийг хэн ч хэзээ ч мэдэхгүй гэж бодож байна.

Тэд хэсэг дуугүй явж, Леголас үргэлж эргэн тойрноо сэрэмжлэн харсаар байв. Хэрэв Гимли сундалдаагүй бол тэр дуртайяа зогсч ойн чимээг сонсох байв.

- Ярих юм алга, гайхалтай модод байна, би энэ ертөнцөд мод гэгчийг үзэхээрээ л нэг болсон доо! Хичнээн төрлийн царсыг мэддэг билээ би! Жаахан саатаж яагаад ч болохгүй юу? Би ойгоор явж, моддын яриаг сонсвол юун тухай ярьж байгааг мэдэж болох сон.

- Үгүй шүү, үгүй! – гэж Гимли яаран хариулаад: - Тэднийг тайван орхи! Би тэртэй тэргүй эдний юу ярьж байгааг мэдэж байна. Эдэнд хоёр хөлтнүүд бүгд дайсан, тэгээд л эд нар биднийг яаж амархан барьж авч дарах вэ гэдгээ л ярьж байна.

- Үгүй дээ, хоёр хөлтэй бүхэн эдний дайсан биш, энийг чи санаанаасаа зохиолоо. Эд нар орхуудыг үзэн яддаг, эльфүүд болон хүмүүс эдэнд огт хамаагүй, эд нар бидний хэн болохыг ч мэдэхгүй. Яаж мэдэх юм бэ? Эд эндхийнх биш, Фангорны бүрхэг ойн гүнд амьдардаг. Эд бол фангорны ой шүү, эрхэм найз Гимли минь.

- Мэдээж, Дундад газрын хамгийн үхэнг газрынх. Сайхан тус хүргэсэнд нь үнэхээр баярлалаа. Гэхдээ л миний сэтгэл эдэнд татагдахгүй байна. Чамд тийм их сонин байгаа бол сонирхож л байхгүй юу. Харин би энэ байтугайг нь үзсэн! Газар дээрх ой, хөндийнүүд юу ч биш! Одоо ч гэсэн тийм юм үзсэндээ баярлахгүй байна. Энэ хүмүүс тун хачин ардууд байна гэж би чамд яриад байгаа шүү дээ. Тэдний хамар дор умард газраас эрээд ч олдохгүй хачирхалтай юм байсаар байтал тэд - агуй! Агуй л гээд байх юм! Дайн болбол хоргодох газар, нөөцийн

агуулах! Миний найз Леголас, Хельмагийн хавцлын хажуу дахь уулсын доогуур ямар эрдэнэсийн өргөөнүүд нуугдаж байгааг чи мэдэх үү? Хэрэв гномууд энэ тухай мэдвэл ертөнцийн газар бүрээс цугларна, орж үзэхийн тулд цэвэр алтаар төлбөр хийнэ дээ!

- Харин би бол тэнд тохиолдлоор орчих юм бол гарахын тулд цэвэр алтаар төлбөр хийнэ.

- Чи ямар тэрнийг үзсэн биш, юугаа мэдэх вэ, тэнэг шогийг чинь уучилъя. Танай Бөглүүд ойн газар доорх хааны ордонг гномууд хийсэн юм, гэтэл тэр эндхийн эрдэнэсийн өргөөнүүдтэй харьцуулахад ердөө л баавгайн ичээ гэсэн үг! Энэ бол аварга том өргөөнүүд, дотор нь өнгө өнгийн урсгалын удаан аялгуу, оддын туяа умбасан Келед-Зарам шиг сайхан нуурнуудын дээрх мөнхийн дуслууд байгаа юм. Бамбарууд асааж, хүмүүс өндөр таазнуудын доорх элсэн шалан дээгүүр явахад гилгэр хананууд нь очир, бадмаараг, болор гээд л эрдэнэс, алт, мөнгөний судлуудаар гялалздаг юм даа, төсөөлж байна уу Леголас. Цааш нь сонс, энд тэндгүй олон өнгөт шалнаас гайхамшигтай сонин хийцтэй мушгиа баганууд цасан цагаан, шар хүрэн, сувдан ягаан өнгөөр зүүд мэт солонгорон босч, багануудын дээрээс усан дулаас бүтсэн мөсөн жигүүр, бөмбөлөг, хөшиг, хөлдүү үүл, цамхаг, туг дарцаг, өлгөөтэй орд өргөө өнгө алаглан шалан дээрх нуурын толин мандалд тусч, тэр нуурын мандалд Дарин л үзсэн байж магадгүй ёроолгүй харанхуйн дээрх ер бусын үзэгдэл - хот, гудамж, баганат орд өргөө өнгө өнгөөр туяарч харагддаг юм. Нэгэн мөнгөн дусал унахад болор тунгалаг усан мандалд хүрээ долгион тархаж, үлгэрийн өргөө тэнгисийн ёроол дахь ургамал шиг найган ганхдаг юм. Үдэш болоход бамбаруудыг аваад явчихна, гайхамшигт үзэгдэл унтарч алга болно, харин өөр нэг өргөөнд шинэ үзэгдэл шинэ өнгөөр солонгорон гялалзана. Тэндхийн өргөөнүүдийг тоолж барахгүй ээ, Леголас минь, ар араасаа л цувраад байна гэж мэд. Уулын гүн рүү мушгирсан шатаар буудаг. Ай даа агуйнууд уу! Хельмагийн хавцлын агуйнууд уу, ай даа! Би энд их азаар ирсэн дээ, тэгээд үзэж чадахгүй явахад уйлмаар байлаа.

- Үнэхээр тийм бол Гимли, дараачийн тулаануудаас амьд мэнд гараад энэ хязгаарт дахин ирж, сэтгэл зүрхний чинь шүтээн болсон агуйнуудаа үзээрэй гэж ерөөе. Харин чи өөрийнхөндөө нэг их яриад хэрэггүй. Чиний ярианаас үзэхэд тэр агуйнуудын юунд ч гар хүрч болохгүй юм байна, алх барьсан хэдэн гном ороод ирвэл ёстой сүйтгэж өгнө биз дээ. Магадгүй, ристаничууд эдгээр уулын агуйнуудынхаа талаар ам ангайдаггүй нь зөв ч юм уу.

- Чи юу ч ойлгосонгүй – хэмээн Гимли уурсаж: - Ямар ч гном тэр өргөөнүүдийг хараад бахдаж биширнэ. Дарины удамд эндээс үнэт чулуу, алт эрдэнэс олборлох гэж санах нэг ч гном байхгүй. Чи хавар гөлөглөж байгаа нялх мод огтлохгүй биз дээ? Энэ чулуун цэцэрлэг бидний хувьд гайхамшигт дархан газар болно. Нүдний цөцгий мэт хайрлан, яаралгүй тайван хаа хэрэгтэй цэгт нь ганц нэгхэн зөөлөн тогшоод л нэг л өдрийн дотор юу хэрэгтэйг нь гүйцээж чадна. Бид яаж ажиллаж чаддагийг чамд үзүүлээд өгөх сөн! Арван жилийн дараа гэхэд л энэ өргөөнүүд жинхэнэ далд сайхнаа ил гаргана, одоо тэр харлаж байгаа харанхуй агуйд шинэ өргөө нээнэ. Энд тэндгүй гэрлээр гийнэ, Леголас! Нэгэн цагт Казад-Думд гэрэлтэж байсан шиг тийм гайхамшигт гэрэл гэгээ гийнэ. Шөнө байхгүй болно, зөвхөн бид л хүссэн цагтаа шөнө болгож чадна.

- Чи намайг бүр мэлрүүлчихлээ, Гимли. Урьд нь чи ийм юм ярьж байхыг би сонсоогүй. Дахиад хэдэн үг хэлбэл тэр өргөөнүүдийг чинь үзээгүйдээ харамсч эхлэх юм байна. За за! Тохиролцье, найдахад бэрх ч гэсэн энэ дайнаас амьд үлдвэл хоёулаа бага зэрэг аялъя. Чи

надтай хамт Фангорны ойгоор, дараа нь би чамтай хамт Хельмагийн хавцлаар.

- Фангорноос би холуур тойрч явмаар байна, гэвч чинийхээр болог - гэж Гимли санаа алдаад:
- Фангорноор эхэлж аялъя, харин дараа нь шууд наашаа ирнэ шүү, би чамд агуй гэж ямар юм байдгийг үзүүлнэ.

- Болж байна – гэж Леголас батлав: - Гэвч бид агуйнуудаас бүр холдчихсон байна шүү дээ, хараач, ойг өнгөрчихлөө. Одоо Изенгард хүртэл хол уу, Гэндалф?

- Хэн явж байгаагаас л хамаарна даа, Саруманы хэрээнүүд шууд нисдэг, тэдэнд бол арвантаван бээр. Хавцлын амнаас гарам хүртэл тав, тэндээс Изенгардын хаалга хүртэл арав. Бид замдаа амарч хононо.

- Тэнд биднийг юу хүлээж байгаа бол? Чи урьдаас мэдэж байгаа, би огт гадарлахгүй байна - гэж Гимли асуув.

- Би мэдэхгүй байна, би тэнд өчигдөр шөнө байсан, тэрнээс хойш олон юм тохиолдож болно. Гэхдээ чи Агларондын гэрэлт агуйгаар оролгүй гарсан боловч тэнд очоод гомдол нэхэхгүй байх.

Тэд ойгоос гарч, Хавцлын амнаас зүүн тийш Эдорас руу, хойшоо Изенгардын гарам руу явдаг Их замын уулзварт хүрэв. Леголас ойн захад жолоогоо татаж, гунигтайгаар эргэж харснаа:

- Тэнд нүд байна! – хэмээн хашгираад: - Мөчрүүдийн цаанаас бидний араас нүд харж байна! Амьдралдаа ийм нүд үзээгүй! – гэв.

Цочсон дайчид жолоо татан эргэж хартал Леголас морио эргүүлэн буцаж давхив.

- Үгүй ээ-үгүй! Бүрмөсөн солиорчихсон юм бол намайг буулга! Тэр нүдтэйгээ далд ор! – гэж Гимли хашгирав.

- Зогс, Бөглүүд ойн ханхүү! Одоо цаг нь биш, энэ ой чамаас зугтаачихгүй – гэж Гэндалф тушаалаа.

Энэ хооронд ойн захад гурван аварга биетэн гарч ирэв. Өндрөөрөө

Троллуудаас арай өндөр, арванхоёр фут орчим, нас гүйцсэн мод шиг бахим чийрэг, урт хөл, урт гартай, олон хуруутай; бариу хувцастай юм уу, арьс нь тийм юм уу, цайвар хүрэн өнгөтэй, саглагар үстэй, урт цайвар саарал сахалтай ажээ. Тэдний асар том нүднүүд морьт дайчид руу биш, умар зүг рүү анхааралтай ширтэж байв. Тэд гэнэт бүрээ үлээж байгаа мэт гараа амандаа хүргэн асар чанга дуугаргав. Бүрээн дутай төстэй боловч илүү урт, уянгалаг байлаа. Хариу бүрээдэх сонсогдлоо. Морьтнууд эргэж, нөгөө тал руу хартал хойт зүгээс тэдэнтэй ижилхэн үлэмж биетнүүд хурдан наашилж байхыг үзэв. Тэд яг өрөвтас шиг алхах боловч хамаагүй хурдан байв. Морьтнууд гайхан дуу алдацгааж, зарим нь илдээ шүүрэв.

- Зэвсгэнд бүү хүр, эд нар зүгээр л малчид. Эд нар бидний дайсан биш, тэгээд ч биднийг огт анзаарахгүй - гэж Гэндалф хэлэв.

Үнэхээр тийм бололтой. Аваргууд морьтнуудыг харсан ч үгүй ой руу орцгоов.

- Малчид! Тэгээд мал сүрэг нь хаа байна? Эд нар хэн юм бэ Гэндальф? Харваас чи тэднийг таньдаг юм байна – гэж Теоден асуув.

- Мод малладаг юм. Эзэн захирагч Теоден минь, үдшийн галын дэргэд домог яриа сонсоогүй удаж ээ дээ, чи? Ристанийн олон хүүхэд шидэт үлгэр, гайхамшигт домгуудыг эргэж санавал чиний асуултанд хариулна даа. Чи сая Фангорны ойн онтуудыг харлаа, танай хэлээр Онтвальд гэдэг юм. Санаандгүй тэгж нэрлээгүй юм шиг чамд санагдаж байна уу? Үгүй ээ, Теоден, итгэж үз. Та нар тэдний хувьд хоромхон зуурын хоосон үзэгдэл, ууган эзэн Эорлын эринээс өвгөн Теоден хүртэлх зуу зуун жилүүд тэдний хувьд нэг өдрөөс ч богино, та нарын үйл хэргийн түүх нарны туяа гялсхийхтэй адил.

- Онтууд! – хэмээн эзэн захирагч удаан дуугүй байсны дараа дуу алдаад: - тийм ээ, үлгэрийн сүүдрүүдийн дунд өнөөгийн гайхамшиг ойлгомжтой, өнөө үе бол урьд өмнө байгаагүй үе. Эрин эринд бид адуугаа өсгөж, газраа хагалж, барилга байшин барьж, илд хадуураа давтаж, аян дайнд мордож гондорчуудад тусалж ирсэн. Үүнийгээ хүний амьдрал хэмээн нэрлэж, ертөнц биднийг тойрон эргэлдэж байгаа гэж боддог байсан. Манай хилийн чанадах ямар ч харийнхныг мэдэхийг ч хүсдэггүй байсан. Эртний үлгэр, дуугаа бид мартаж, зөвхөн хэсэг бусаг нь л хүүхдүүдийн чихэнд тохиолдлоор хүрдэг байж. Ингээд эртний домог амилж, гэгээн цагаан өдөр нүдний өмнө ил гарлаа.

- Тэгвэл баярла даа, эзэн захирагч Теоден, өнөөгийн энэ аймшигт аюул зөвхөн богино наст хүмүүний төрөлд төдийгүй та нарт үлгэр гэж санагддаг байсан өөр амьдралд ч заналхийлж байна. Та нарт өөрсдийн чинь зүүдлээ ч үгүй холбоотнууд, хамтран тэмцэгчид байна.

- Баярлах уу, гуних уу гэдгээ мэдэхгүй л байна шүү, бид яллаа ч гэсэн Дундад газрын амьдралаас олон гайхамшигтай сайхан юм алга болно.

- Алга болно, Сауроны хорт муу үйлийн үрийг үндсээр нь тасдаж чадахгүй, тэрний ул мөр арилшгүй. Гэвч энэ бол бидний хувь тавилан. Хувь тавилангийнхаа өмнөөс явцгаая даа!

Ой ургасан хавцлын ам ард хоцорч, зүүн тийш гарам руу эргэлээ. Леголас араас нь байн байн эргэж харсаар давхиж явна. Нар шингэж, тэд уулын бэлээс холдсон хойноо эргэж харвал Ристанийн хаалганы цаана тэнгэр улайрч, үүл туяарч байв. Сүрэг хар шувууд эргэлдэн нисч, тэдний дээгүүр таран, хадан цохионууд руугаа гомдолтой хашгиралдан буцаж байв.

- Дайны талбарт ханаж цадталаа найрлаарай - гэж Эомер хэлэв.

Тэд харанхуйлж буй талаар хатирууллаа. Бага зэрэг хомс сар удаанаар хөөрч, мөнгөлөг гэрэлд нь хээр тал саарал давалгаа хаялж харагдана. Дөрвөн цаг орчим хатируулаад гарам дээр ирлээ. Салхин талаас чонын тасалданги улиан сонсдож, ристаничууд энэ газарт хичнээн эрэлхэг дайчид ясаа тавьсныг гуниглан санав. Зам эргийн даланг огтлоод гол руу мушгиралдан орж, нөгөө эргээс уул өөд өгсчээ. Чулуугаар тавьсан гурван нарийхан зөрөг болон морин гарам голын дундах нүцгэн аралд хүргэлээ. Морьтнууд гарам руу хараад ихэд гайхав. Урьд нь том том бул хаднуудын дундуур гол эрчлэн шуугидаг байсан бол одоо анир

чимээгүй байна. Усгүй голдрилд голын бөөрөнхий чулуу, элсэн ёроол ил харагдана.

- Уйтгартай газар болж дээ, танигдахааргүй болж. Саруман чадах бүхнээ сүйтгэсэн байна. Изенийг хашиж, ундаргыг нь хордуулсан юм болов уу? - гэж Эомер асуухад:

- Тэгсэн л юм шиг байна - гэж Гэндалф хариулав.

- Бид заавал энэ замаар, анд нөхдийнхөө зовсон шарилын хажуугаар явах хэрэг байна уу? – гэж Теоден асуухад:

- Хэрэгтэй, бид энэ замаар явах хэрэгтэй. Чиний сэтгэлийн зовлонг ойлгож байна. Гэвч уулын чононууд манай дайчдын шарилд хүрээгүйг үзэх болно. Тэд өөрсдийнхөө найз орхуудын шарилыг иддэг юм. Тэд амьдралын төлөө биш, үхлийн төлөө тэгж л нөхөрлөдөг юм даа – гэж Гэндалф хэлээд: Урагшаа! – хэмээн захирав.

Тэд гол руу бууж ирэхэд чонын улиан чимээгүй болов. Сарны гэрэлд цагаан өмсгөлт Гэндалф болон цагаан мөнгөн зүст Аянга дэндүү сүрлэг харагдсан учир чононууд зугтжээ. Морьтнууд арал дээр гарахад чононуудын гэрэлт нүд өндөр эрэг дээрээс араас нь харж байв.

- Хараач! – хэмээн Гэндалф заагаад: - Андууд чинь зүүрмэглээгүй байна – гэв.

Арлын дунд чулуугаар хүрээлэн шинэхэн босгосон хиргисүүр дээр жаднууд хатгасан байхыг дайчид харлаа.

- Тулалдаанд амь үрэгдсэн бүх мустангримчүүд энд нойрсч байгаа - гэж Гэндалф хэлэв.

- Амгалан нойрсох болтугай! Тэдний жад зэвэрч үжрэх боловч хиргисүүр нь Изенгардын гармыг мөнх манахаар үлдэх болно – гэж Эомер хэлэв.

- Энэ бас л чиний зүтгэл үү Гэндалф, үнэлж баршгүй анд минь? – ганц шөнийн дотор их үйлс бүтээлээ дээ! – гэж Теоден хэлэхэд:

- Аянга болоод нэрийг нь мэдэхгүй бусад туслагчдад баярлалаа - гэж Гэндалф өгүүлэв:

- Ажил ч их байсан шүү - амжуулах л хэрэгтэй байлаа! Энэ уулын дэргэд чиний санааг өргөх нэг юм хэлье. Дам сураг хохирлын тоог гурав дахин ихэсгэсэн болохоос биш үнэндээ тийм ч олон дайчин амь үрэгдээгүй байна лээ. Харин их тарсан байсан. Би цуглуулж чадах бүгдийгээ цуглуулсан. Заримыг нь би Гримбладаар удирдуулж Эркенбрандад туслуулахаар явуулсан, бусдад нь оршуулга үйлдэх даалгавар өгсөн. Одоо тэд Эдораст ойртож яваа. Чиний жанжин Эльфхельм удирдаж байгаа, араас нь бас морьт дайчдын өөр нэг зуут явуулсан. Саруман Хельмагийн цамхаг руу бүх цэргээ явуулсан, бүр жижиг отрядуудаа эмхэлж илгээсэн байна лээ. Гэлээ ч гэсэн би ямар нэг санаанд оромгүй дээрэмчид юм уу, сүрэг чонодолоох хамгаалалтгүй нийслэл рүү дайрах вий гэж айж байсан юм. Одоо айх юм байхгүй. Орд өргөө чинь чамайг бүрэн бүтнээрээ хүлээж байгаа.

- Би түр ч гэсэн өвөг дээдсийнхээ алтан тоонот өргөөндөө эргэж очиход их баяртай байх болно.

Арлаас хөдлөөд гол гаталж, өндөр эрэг өөд өгсөв. Тэднийг дөнгөж явангуут чононууд дахин хорсолтой ульж хоцорлоо. Аль эрт цагт Изенгардаас гарам хүртэл зам тавьсан байжээ. Тэр зам голын дагуу явж, зүүн тийш эргээд дараа нь хойт зүг рүү эргэж, эцэст нь голоос холдож, хөндийн баруун захад байгаа Изенгардын хаалга руу шууд хөтөлдөг байжээ. Дайчид тэр замаар биш, шинэхэн өвс өтгөн ургасан хээр талаар явлаа. Түрүүчийнхээсээ хурдан урагшилж, шөнө дунд гэхэд элбэг таван бээр давхилаа. Тэгээд Манант уулын бэлд хоноглов. Эзэн захирагч багагүй ядарсан байлаа. Тэдний өмнөөс Нан-Курунирын урт үзүүр тосч, хөндийг өтгөн харанхуй нөмөрчээ. Сар баруунаа тонгойж уулсын цаагуур оров. Харанхуйд хучигдсан хөндийгөөс нүсэр их утаан багана хөөрч, тэнгэрт гараад замхарч байлаа.

- Энэ юу вэ, юу гэж бодож байна, Гэндальф? – гэж Арагорн асуугаад: - Илбийн хонхор тэр чигээрээ шатаж байгаа юм шиг.

- Одоо энэ хонхроос цаг үргэлж бөөн хар утаа манарч байгаа - гэж Эомер хэлэв: - Гэвч би энэ утааг хараагүй юм шиг байна. Утаа нь бага, тэр чигээрээ уур байгаа биз дээ. Саруман бас нэг шинэ юм бэлтгэж байгаа. Бодвол Изений усыг буцалгаж байгаа байх, тэгээд л гол хуурайшчихгүй юу.

- Бүгдийг нь буцалгачихсан ч байж мэднэ, Изен яасныг маргааш өглөө мэдье. Харин одоо амарцгаахыг бод – гэж Гэндальф өгүүлэв.

Изен гол урсч байсан хуурай голдрилоос холгүй хоноглов. Нойр нь хүрсэн зарим нь унтаж байтал шөнө дунд харуулууд тэднийг сэрээв. Сар жаргажээ. Одоод гялалзаж байсан ч шөнийн харанхуйгаас ч хар харанхуй голын хоёр талаар хойт зүг рүү мөлхөж байв.

- Хөдөлж болохгүй! Зэвсгэнд бүү хүр! Хүлээж бай, одоохон өнгөрнө! – гэж Гэндальф захирлаа.

Тэднийг битүү манан бүрхэв. Дээр хэдхэн саарал од анивалзаж, хоёр талаар харанхуй хавчина. Тэд аварга том хоёр сүүдэрт хавчигдсан нарийхан шуудуунд байгаа юм шиг санагдана. Шивнэлдэх, үглэх, хүнд, уртаар санаа алдах сонсогдоно. Газар хариу өгөх мэт удаанаар чичигнэж байлаа. Тэдний айдаст авгсан хүлээлт төгсгөлгүй юм шиг санагдаж байтал харанхуй замхарч, дуу чимээ намдан тэртээ уулын хаа нэгтээ шингэх шиг болов.

Өмнө талд, Горнбургийн ойролцоо шөнө дунд аянга нижигнэн, хөндийгөөр хар шуурга хуухиран өнгөрөх шиг болоод газар доргин чичирлээ. Бүгд айдаст автаж, цааш юу болохыг хүлээв. Өглөө нь юу болсныг харахаар бүгд хартал гайхмаар юм болжээ. Ид шидийн ой алга болж, орхуудын хүүрэн уул ч оргүй алга болжээ. Тэртээ доор үлэмж биет малчид тоомшгүй олон сүрэг тууж өнгөрсөн мэт өвс ногоо талхлагдаж, Гатигаас цааш нэг бээр орчим зайд аварга том хонхор үүсч, дээр нь хайрга асгасан байв. Алагдсан орхуудыг тэнд булсан байх гэж ярилцах авч ой руу гүйж орсон үй олон орх хаашаа алга болсныг хэн ч хэзээ ч мэдсэнгүй, тийшээ нэг ч хүн зүглэсэнгүй, тэнд дахиад ногоо ургасангүй билээ. Тэр газрыг түүнээс хойш Үхдлүүдийн нүх гэх болсон юм. Хавцлын аман дахь ер бусын моддыг ч дахиж харсангүй, шөнө ирсэн шигээ Фангорн руугаа буцжээ. Тэд орхуудаас өшөөгөө аймшигтайгаар авсан юм.

Үүний дараа эзэн захирагч болон дайчид унтаж чадсангүй, шөнө нам гүм өнгөрч үүр цайхын

өмнөхөн гол хүржигнэн шуугив. Бул чулуу, хайрга усаа ханатал залгилж, дараа нь ус голдрилоо дүүргэв. Изен юу ч болоогүй юм шиг ажил хэрэгчээр урслаа.

Үүр цайхад тэд мордохоор бослоо. Цайвар саарал манангийн цаана нар мандаж байгаа бололтой. Тэгш өргөн замаар аажуухан хөдлөв. Зүүн талаар манангийн цаанаас урт нуруу бараантаж харагдав: Нан-Курунир буюу зөвхөн өмнө талаасаа нээлттэй Илбийн хонхорт орж иржээ. Нэгэн цагт энэ хонхор нов ногоон байж, Изен голд цутгадаг олон горхи булаг, уулнаас буусан хурын үер энэ хөндийг умдаалан тариа тарьж, үржил шимийг нь хүртдэг байв. Гэвч тэр цаг өнгөрөөд уджээ. Одоо Изенгардын ханын дэргэд Саруманы боолуудын тариалан байдаг, хөндийн бусад газарт чононууд эзэн суужээ. Урьд нь энд өтгөн шугуй байсны ул мөр түлэгдсэн хожуулууд харлаж харагдана. Гагцхүү Изен л энэ гунигт орчинг чулуун эргийнхээ дотор тонгочин сэрээж байна. Утаа, уур багсран хөөрч, нам дор газарт сууж байна.

Дайчид чимээгүй, тэдний зүрхэнд эргэлзээ төрж, яах гэж биднийг энд авчирсан юм бол, энэ бүхэн юугаар дуусах бол хэмээн гайхаж байгаа бололтой. Хэдэн бээр явсны дараа зам чулуун хашлагат гудамж болон хувирч, чулуун хавгангуудын завсраар нэг ч өвс үл цухуйжээ. Гудамжны хоёр талаар гүн шуудуугаар ус урсана. Манан дундаас нэгэн аварга том багана тодров. Хар чулуун суурин дээр асар том чулуу босгож урт цагаан даль маягийн юм цохиж, цагаан будаг нялжээ. Түүний долоовор хуруу хойт зүг рүү зааж байв. Изенгардын хаалга хүртэл бага зай үлдсэн гэдгийг дайчид мэдэж байсан бөгөөд тийшээ ойртох тусам сэтгэл нь улам үймэрч, өмнө нь зөвхөн өтгөн манан хана туурга мэт хөшиглөн байв.

Илбийн хонхорт олон мянган жилийн өмнөөс Изенгард нэртэй цайз сүндэрлэж ирсэн ба нуменорын барилгачид түүнийг босгож, дараа нь энд тийм ч муу барилгачин биш Саруман олон жил эзэн сууж байгаа юм. Олон хүн хамгийн дээд, хамгийн мэргэн шидтэн гэж биширдэг байсан Саруманы үед энэ цайз ямар байв? Хадан хясаанд аварга том хадан цагариг нүхлэн орж, дотогшоо орох зөвхөн ганц орц - Өмнө талын том нуман хаалга, түүний доогуур хадан хясаа руу нүхэлж орсон хонгил, түүний хоёр талаасаа нүсэр зузаан ширмэн хаалгатай. Зузаан ган жааз нь хадан хөрсөнд гүн сууж, хаалганы самбар нь асар том нугасанд дүүжлэгдсэн тул дөнгөж гар хүрэхэд л чимээгүй бөгөөд хурдан нээгддэг. Гаднаас ирсэн хүн нэг захаасаа нөгөө захаа хүртэл элбэг нэг бээр зайтай аварга том аяганы ёроолд орсон юм шиг санагдана. Эрт цагт энд жимсний цэцэрлэг алаглаж, уулнаас буусан горхинууд шулганан урссаар том нууранд цутгадаг байжээ. Гэвч Саруманы эзэмшлийн үеэс тэр бүхэн үлгэр домог болж, цэцэрлэгийн дундах зөргүүдийн оронд хар чулуун зам тавьж, жимсний цэцэрлэг оргүй болоод оронд нь гантиг, зэс, төмөр баганууд босгож, хооронд нь хүнд гинжээр холбожээ.

Цайзыг тойрсон нүсэр том хадан хясаануудыг дотроос нь үй олон нүх, хонгил ухан гаргаж, элдэв агуулах, нууц байрнуудыг холбожээ. Эргэн тойронд элдвийн жижиг барилга шавааралдуулан барьж, тоомшгүй олон хар хаалга, онгорхой цонх гаргажээ. Тэнд олон мянган зарц барлаг, боолууд, цэргүүд байрлаж, зэвсэг хадгалж, газар доорх нүхэн хонгилуудад чоно тэжээдэг ажээ. Хад чулуун байгууламжуудын шал, ёроолыг бас л нүхэлж, уурхайнууд болгосон ба сарны гэрэлд Изенгард түгшүүрт булш мэт харагдана. Газар тасралтгүй доргин чичирхийлж, мушгиа шатнууд газар доорх агуулах, зэвсгийн дархны газар, хөөргөнүүд рүү оржээ. Төмөр бул, дугуйнууд эргэж, алх, лантууны чимээ үл тасарна. Цооног, нүхнүүдээс хар утаа олгойдож, улаан хүрэн, хар хөх, хар ногооноор манантана.

Тийм гэж хэлэхийн аргагүй ер бусын хачин хэлбэр дүрстэй асар том цамхаг хамгийн дээр нь байх бөгөөд түүнийг Изенгардын хэрмийг барьсан эртний барилгачид босгосон ажээ. Газраас ургаатай зургаан талт дөрвөн аварга багана тэрхүү гялгар хар ханатай цайзыг үүсгэсэн байна. Таван зуун фут өндөрт кинжаалын үзүүр шиг хэлбэртэй олон салаалсан гонхнууд байх бөгөөд гол дунд нь дугариг талбай, түүний толь шиг гялгар гадарга дээр нууцлаг бичээс байна.

Саруманы энэ баргар цайзыг Ортханк гэж нэрлэдэг ба заяа тавилангаар ч тэр үү, эсвэл тохиолдлоор уу, бүү мэд эльф хэлээр Соёо уул гэсэн утгатай, эртний ристани хэлээр Заль ухаан гэсэн утгатай болдог ажээ.

Балар эртний аварга хүчирхэг цайз Изенгард олон мянган жил сүр бараагаа гайхуулан оршиж, энд Гондорын баруун хязгаарыг хамгаалагч агуу жанжингууд, одтой яригч мэргэд суудаг байжээ. Гэтэл Саруман энэ цайзыг удаан бөгөөд шургуу зүтгэлээр өөрийнхөө хорон санаат төлөвлөгөөнд тохируулан өөрчилж, өөрийгөө эгнэшгүй их уран барилгач хэмээн боддог ажгуу.

Гэндальф далийн дүрстэй баганын дэргэдүүр өнгөрч гарахад дайчид тэрхүү даль нь цагаан будаг ч биш хатсан цус, хумснууд нь улаан болохыг ажиглав. Гэндальф манан дундуур ороход дайчид араас нь дургүй ч гэсэн дагалаа. Эргэн тойронд их бороо орсны дараахь шиг хонхор хотгор бүхнээр ус дүүрч, чулуун хашлага дотуур ус шоржигнон урсана.

Эцэст нь Гэндальф зогсч наашаа ир гэсэн дохио өгөхөд тэд манангаас гарч түүн рүү очив. Үдээс хойшийн цонхигор наранд Изенгардын хаалга харагдав. Хаалга ч гэж дээ хаалга гэх юм байсангүй, нугаснаасаа салсан, хэмхэрхий нүсэр зуун ширэм замбараагүй их эвдэрхий хэмхэрхий төмөр сэгэн дунд хэвтэж байна. Нуман хаалга нь бүтэн, түүний цаана дээвэр нь алга болсон хонгил байна. Хоёр талынх нь хана цөм цөм хэмхэрч, харуулын цамхаг нь нурж юу ч үгүй болжээ. Далайн ус хамгийн их хүчтэй шуурганд туугдан уулын бэхлэлт рүү дайрсан ч ийм их эвдрэл гаргахааргүй.

Хагас нурсан хадан бэхлэлт дотор утаа манарч, усаар дүүрсэн асар том хүнхрээс уур савсаж, элдвийн гуалин, дүнз, авдар сав, бусад есөн жорын юмс хөглөрөн хөвнө. Үер дотроос муруйж тахийсан баганууд цухуйж, бүх зам үерт автан, чулуун арлын дунд уур манан харанхуйлжээ. Гэвч Ортханкийн цайз бүрэн бүтнээрээ дүнхийж, булингарт ус ханыг нь долоож байлаа.

Эзэн захирагч болон морьт дайчид энэ бүхнийг хараад гайхаж гүйцэв. Саруманы эзэмшил харсаар байтал дууссан бололтой, харин хэн яаж ингэж сүйтгэсэн юм бол? Тэд нэг сайн хартал эвдэрхий хэмхэрхий, хог новшин дотор бараг чулуунаас ялгарахааргүй саарал хувцастай хоёр жаалыг харав. Тэр хоёрын дэргэд лонх, аяга, таваг хөглөрч харагдах бөгөөд мань хоёр дөнгөж сая нэг сайн хооллож аваад одоо амарч байгаа бололтой. Нэг нь зүүрмэглэж байгаа бололтой, нөгөө нь хөлөө ачиж, гараа толгойн ардаа салаавчлаад, амнаасаа утаан үүл, цагариг гарган зугаацаж байна.

Теоден, Эомер болон бусад ристаничууд мэл гайхав. Ийм юм нэг удаагийн зүүдэнд ч багтахгүй, тэр тусмаа сүйрсэн Изенгард дотор. Гэвч эзэн захирагч үг дуугарч амжаагүй байтал утаа гаргагч жаал манан дундаас гарч ирсэн морьт дайчдыг хараад ухасхийн босов.

Харваас идэр насны залуу мөртөө тал хүний дайтай тэр жаал толгой нүцгэн, буржгар хүрэн үстэй, Гэндалф болон түүний дагуулууд Эдораст ирэхдээ өмссөн байсан шиг саарал цувтай байв. Тэр хоёр гараа цээжин дээрээ аваад гүнээ мэхийв. Дараа нь шидтэн болон түүний дагуулуудыг хараа ч үгүй юм шиг Эомер болон эзэн захирагчид хандаж:

- Изенгардад тавтай морилогтун, эрхэм ноёд оо! Бид хоёр энд харуулын үүрэг гүйцэтгэж байна. Намайг Сарадокийн хүү Мериадок гэдэг, миний зэвсэгт нэгт нөхрийг алдарт Молтогчин овгийн Паладины хүү Перегрин гэдэг гэснээ: - Өө энэ чинь нойрондоо дийлдчихэж – гээд зэвсэг нэгт нөхрөө нэг сайн өшиглөв. Манай нутаг алс умард газарт байдаг. Цайзын эзэн Саруман цайздаа байгаа, гэхдээ тэр хэн нэгэн Өмхий Амттай тэндээ нуугдчихаж, тэгээгүй сэн бол ийм хүндэт зочдыг хүлээж авах ёстой доо – гэлээ.

- Тэгэлгүй яахав, мэдээж хүлээж авах ёстой! – хэмээн Гэндалф тачигнатал инээснээ: - Ингэхэд Саруман чамайг лонх, таваг хоёроос салж чадвал хэмхэрхий хаалга манаж, зочдыг хүлээж авахаар томилсон хэрэг үү?

- Үгүй ээ эрхэм ээ, тэр энэ талаар тушаал өгөхийг хүсээгүй, тэр дэндүү завгүй байсан. Өршөөгөөрэй, хаалган дээр бид хоёрыг хэн нэгэн Модон, Изенгардын өнөөгийн захирагч тавьсан юм. Тэр надад Ристаниин эзэн захирагчийг зохих ёс журмаар угтаж ав гэж тушаасан, би алдаа гаргаагүй гэдэгтээ найдаж байна, тийм үү?

- Чи найз нар руугаа, Леголас руу, над руу нулимж байна уу! – гэж тэвчээр алдарсан Гимли хашгираад: - Аа хоёр муу новш, үст өсгийт, үст тавхайт залхуучууд! Бид та хоёрын буянаар ёстой тавхайгаа эргэтэл гүйсэн дээ! Ой, намаг дундуур, дайн тулаан, үхэл дундуур та хоёрыг аврах гэж гүйсэн! Гэтэл та хоёр энд юу ч болоогүй юм шиг найрлаж хэвтээд, бас тамхи татаж эрхэлж байна уу! Тамхи шүү дээ, бодоод үз! Хаанаас тамхи олсон бэ, хоёр зэвүүн амьтаан? Аа муу алх барьсан хачиг чамайг даа, өөр хэлэх үг алга! Би баяр хөөр, уур хилэнгээсээ болоод дэлбэрчихгүй л бол жинхэнэ гайхамшиг гэгч болно вий!

- Чи их зөв ярьж байна Гимли - хэмээн Леголас түүнийг дэмжиж: - Үгүй ер, дарс хаанаас олдог байна аа?

- Гүйхдээ ч үнэхээр лут юм, ухаанаа гүйлгэхдээ тааруухан юм даа - хэмээн Пин өрөөсөн нүдээ нээнгээ хэлээд: - Бид хоёр ялалт байгуулчихаад, тулааны талбарт есөн жорын олзны дунд сууж байхад байлдаж авсан олзыг маань хаанаас олсон бэ гэж асуудаг байна шүү?

- Байлдаж олсон гэв үү? - хэмээн Гимли дэлбэртлээ уурлаж: - Тэр ч харин үгүй байх шүү!

Морьт дайчид нижигнэтэл инээлдэв.

- Эргэлзэх юм алга, бид хуучин андуудын уулзалтын гэрч боллоо – гэж Теоден хэлээд - Чиний алга болсон хоёр дагуул чинь энэ хоёр биз дээ Гэндалф? Тийм ээ, өнөө үе гайхамшгаар дүүрэн байна. Би Эдорасаас гарснаас хойш эднийг хангалттай харлаа, харахгүй юу, дахиад л гэгээн цагаан өдрөөр үлгэр домгийн ардууд гараад ирлээ. Та хоёр нөгөөх жижиг биетүүд, манайхны хэлдгээр хольбитлууд уу?

- Хоббитууд шүү, эрхэм та зөвшөөрвөл – гэж Пин засав.

- Хоб-битууд? - гэж Теоден итгэлгүйхэн давгаад: - Танай хэл хачин их өөрчлөгджээ, гэхдээ энэ нэр та нарт бүрэн тохирно. Хоббитууд юм биз дээ! Хэл хэлээрээ, үнэн түүнээс гайхамшигтай.

Мерри мэхийн ёслоход Пин босч дуурайв.

- Таатай сайхан үг хэллээ эзэнтэн минь, би таны үгийг зөв ойлгосон гэж найдаж байна. Тун ч гайхалтай учрал байна! Бид ингэж их урт удаан аялахад хоббитуудын тухай юухан ч атугай мэддэг хүн анх удаа тааралдлаа.

- Миний өвөг дээдэс умард нутгаас гаралтай. Гэхдээ би чамайг хуураад яах билээ, бид ч гэсэн хоббитуудын талаар бага мэднэ. Холын хол уулс, цэнхэр голуудын цаана элсэн манхны доогуур нүх ухаж амьдардаг жижиг биет хүмүүс байдаг л гэж сонссон. Та нарын ажил амьдралын талаар мэдэх юм байхгүй, тэдний талаар угаасаа яриад байх юм байхгүй гэдэг, та нар хүний бараа харвал нүд ирмэх зуурт нуугдчихдаг, шувуудын дууг гайхалтай адилхан дуурайдаг гэж сонссон юм байна. Та нарын талаар өөр бага сага юм ярьж чадах л байх.

- Чиний үг алт шиг сайхан сонсогдож байна – гэж Мерри хэлэв.

- Ядаж та нарыг амнаасаа утаа гаргаж чаддаг гэж сонсоогүй юм байна.

- Энэ ч гайхаад байх юм байхгүй дээ, энэ урлагт хэтэрхий эрт цагт суралцсан юм. Өмнөд тойргийн Уртсүүлтийнхний Тобольд Аянганиргэгч анх цэцэрлэгтээ жинхэнэ тамхины ургамал тарьсан гэдэг юм. Энэ бол манай тооллоор нэг мянга долоон зуун оны хавьд гэсэн үг. Хөгшин Тоби энэ өвсийг олсон тухайд бол...

- Чи болгоомжтой байсан нь дээр байх, Теоден – гэж Гэндальф ярианд оролцоод: - Хоббитуудад боломж олгох л юм бол тулалдааны талбарт ч хамаагүй сууж аваад л хоол унд гал тогооны тухай ам хуурайгүй ярихаас гадна далимд нь өвөг эцэг, элэнц хуланцууд, эцэг, эхийнхээ талаас арван үе тасарсан холын хамаатнуудынхаа намтар түүхийг хуучилж амжина. Тэд тамхинд яаж орсон талаар дараа сонсьё. Мерри, Модон хаана байгаа вэ?

- Хойт зүгт хаа нэгтээ байгаа байх гэж би бодож байна – хэмээн Мерри бодлогошронгуй хариулав: - Тэр цэвэр ус уухаар явсан. Онтууд түүнтэй хамт Изенгардыг гүйцээн нурааж байгаа – тэнд л байгаа болов уу – хэмээн Мерри утаа манантаж байгаа нуур руу заав. Тэд чагнавал тэр зүгээс нижигнэсэн их чимээ сонсогдож байв. Бүрээ ялалтын мэдээ өгч байгаа юм шиг хру-у-умм, хуу-мм! – хэмээн уртаар уянгалан цуурайлна.

- Ортханкийг харуул хамгаалалтгүй орхисон хэрэг үү? – Гэндальф ширүүхэн асуув.

- Тэнд ус харуул хийж байгаа, ганц ус ч биш. Хурдан тэнд нөхөдтэйгээ цамхгийг манаж байгаа. Чи сайн хар л даа, тэнд Саруманы баганууд л гозойж байна гэж бодоод байгаа юм уу? Хурдан хясааны дэргэд шатны доор зогсч байна...

- Тийм байна, өндөр саарал онт зогсч байна – хэмээн Леголас батлаад: - гараа унжуулаад зогсчихсон учир баганаас ялгарахгүй байна.

- Аль хэдийн үд болчихож, бид та хоёроос ялгаатай нь өглөөнөөс хойш юу ч идээгүй. Гэвч би эхлээд Модонтой уулзах хэрэгтэй байна. Тэр надад юу ч хэлүүлээгүй юу, эсвэл чи идэж ууснаасаа болоод мартчихсан уу?

- Тэр заавал хэлээрэй гэж захисан юм бий шүү. Намайг асуултаар булаагүй бол би аль хэдийн чамд дамжуулах байсан юм. Хэрэв Ристаниин эзэн захирагч болон Гэндалф Изенгардын хойт захад очвол Модонтой тэнд уулзана, тэр та нартай уулзахдаа их баяртай байх болно гэж дамжуул гэж надад тушаасан. Таны дуулгавартай зарц бидний олж, сонгож бэлтгэсэн онцгой сайхан хоол хүлээж байгаа – гээд Мерри дахин мэхийв.

- Аль түрүүн ингэж хэлэх байсан юм! - хэмээн Гэндалф инээж: - За Теоден, явцгаая, Модон дээр очъё! Тойрч явах боловч ойрхон, Модонтой уулзаад олон юмыг мэдэж авна. Учир нь тэр бол өдгөө амьд байгаа хамгийн эртний онтуудын нэг Фангорн шүү дээ.

- Тэгье, баяртай, холь... хоббитууд аа! Миний өргөөнд дахин уулзаж магадгүй. Тэгвэл та хоёр хажууд минь завилж суугаад юу дуртайгаа яриарай. Өвөг дээдсийнхээ тухай, санасан болгоноо яриарай. Хөгшин Тобольдын тухай ч, татдаг өвсний тухай түүний сургаалыг ч хөөрөлдье. Баяртай ноёд оо!

Хоббитууд гүнээ мэхийн ёслов.

- Ристаниин Эзэн захирагч чинь ийм хүн байдаг юм бий! Ямар сайхан зантай юм бэ? Ёстой сайхан өвгөн байна даа! – гэж Пин аяархан өгүүлэв.

Бүлэг 9

Хог новш, үнсэн товрог

Гэндальф Эзэн захирагч хоёр дайчдаа дагуулан эвдэрч нурсан Изенгардын хэрмийг тойрч Модонг хайхаар явахад Леголас, Гимли, Арагорн гурав морьдоо өвс идүүлэхээр явуулаад хоёр хоббиттай хууч хөөрөхөөр суув.

- Та хоёрыг хөөсөөр байгаад гүйцэх нь ч гүйцлээ, харин яаж яваад энд ирчихсэнийг чинь бодоод бодоод ухаан хүрэхгүй нь - гэж Арагорн хэлэв.

- Тийм шүү - хэмээн Леголас түүний үгийг шүүрч аваад: - Энэ ертөнцийн эрхтэн, хүчтэнгүүд агуу үйл хэргээ хэлэлцэж л байг, харин гурвуулаа энэ хоббитуудын араас тамтагаа цайж ирсний хувьд баригдсан дээр нь гэдэс дотрыг нь уудалъя. Энэ чинь юу гэсэн үг вэ, бид Харанхуй ой хүртэл эднийг дагасан гэж хэлж болно, гэтэл оньсого олшроод л байдаг.

- Харин бид хоёрт араас хөөдөг анчин та нарын паян сонин байна, хамгийн хөгшин онт Модон бид хоёрт бага сага юм тайлбарласан шүү, одоо та нарын ярих ээлж - гэж Мерри эсэргүүцэв.

- Бидний ээлж гэв үү? – хэмээн Леголас уурлаж: - Хэн та хоёрын араас хэлээ унжуулж гүйсэн бэ? Бид гурав та хоёрын араас, тэгэхээр эхлээд та хоёр яриад бай даа.

- Эхлээд биш ээ, дараа нь – гэж Гимли хэлэв: - Хоол идсэний дараа яриа сайхан өрнөдөг юм. Миний толгой өлссөнөөс болоод өвдөж байна, тэгээд ч одоо яг үдийн хоолны цаг. Хийх ажилгүй уйдсан хоёр баатар минь идэж ууж болох бүхнийг аваад ир, дайны олз гээд л гайхуулаад байсан биз дээ, яаж уудгаа үзүүлээд өгье, уухаараа улам сайхан зантай болно, хараарай.

- Одоохон бид хоёр чамайг сайхан зантай болгоод өгнө, харин хаана идэж уух вэ, энд үү, эсвэл тэр харагдаж байгаа Саруманы харуулын байр байсан газарт уу? Бид хоёр та нарыг харалгүй өнгөрөөчихгүйн тулд энд байрласан юм – гэж Пин яаран хэлэв.

- Тэгээд өнгөрөөчихөө биз дээ! – хэмээн Гимли уурлаж: - Би ямар ч байсан орхуудын байранд ч, үхдлүүдийн байранд ч зочлохгүй, тэдний хоолны шавхрууг долоохгүй.

- Хэн чамайг орхуудын байранд оруулах гэсэн юм бэ? - гэж Мерри асуугаад: - Бид хоёр ч гэсэн орхуудаас сэжиглэдэг болсон. Изенгардад хог новшнууд хос хосоороо байсан юм. Саруман хүртэл орхууддаа итгэдэггүй байсан, хаалганы манаач, хамгаалагчаар хүмүүс ажилладаг байсан. Тэднийг сайн тэжээдэг байсан юм шүү.

- Бас татдаг өвсөөр хангадаг байсан уу? - гэж Гимли ёжтой асуув.

- Үгүй, хангадаггүй байсан - гэж Мерри инээгээд: - Гэвч энэ бол үдийн хоолны дараа ярих асуудал.

- За за, ятгаж дөнгөлөө, явж хооллоё! – гэж гном хэлэв.

Тэр гурав хоббитуудыг дагаж нуман хаалганы доогуур зүүн тийш эргээд шатны цаанах том тулгатай, хоёр хаалгатай том танхимд оров. Тэнд урьд нь цаг үргэлж харанхуй байсан бололтой, цонх нь хонгил руу харсан боловч одоо ханыг нь цөм цохисон учир нарны гэрэл хангалттай орж байлаа. Тулганд гал дүрэлзэж байв.

- Энэ галыг би асаасан юм. Галын дэргэд суухад аятайхан, харанхуйд бол бүр ч сайхан – гэж Пин сайрхаж: - Харин мөчир бага, түлээ нойтон, аз болоход яндан нь хага үсэрсэн болохоор гал сайн асч байна. Одоо гал маш хэрэгтэй, би та нарт бин хайрч өгье, талх нь хатчихсан байна, бодвол гурван жилийн өмнө жигнэсэн юм шиг байна.

Арагорн болон түүний дагуулууд нэгэн урт ширээнд сууж, хоёр хоббит хаалганы цаагуур алга болов.

- Тэнд эдний гал зуух байдаг юм, аз болоход усанд автаагүй – гэж Пин тайлбарлаад аяга таваг, халбага сэрээ, таваг авчирч өрөв. Араас нь Мерри тавиуртай хоол унд авчирлаа.

- Сэжигтэй харах хэрэггүй, эрхэм ноён Гимли, энэ бол орхуудын хоол биш, Модонгийн хэлдгээр жинхэнэ хүмүүний хүнс. Дарс уух уу, пиво уух уу? Нэг сайхан торх дүүрэн пиво байна, дажгүй шүү. Бас онцгой сайн даруулга ч байна. Гахайн мах шаруулах уу? Харин хачир тааруухан шүү. Ойрдоо энд шинэ хүнс авчраагүй! Махнаас өөр талх, цөцгий, зөгийн бал л байна. Болно биз дээ?

- Энэ муусайн хоббитууд уу! Идэх юмыг иддэг ч, мэддэг ч - гэж Гимли хэлэв.

Мань гурав амьдралдаа ганцхан удаа идэж байгаа юм шиг идсэн боловч гайхалтай нь гэдэс нь хагарах шахсан хоёр хоббит тэднээс огтхон ч хоцорсонгүй.

- Хүссэн ч, хүсээгүй ч зочдоосоо хоцорч болохгүй – гэж хоббитууд дараа нь санаа алдан хэлэв.

- Мөн ярив аа, яасан зочломтгой эзэд вэ, бид нар ирээгүй байсан ч та хоёр яаж ийгээд л хагартлаа идэх байсан даа – хэмээн Леголас хөхрөв.

- Яагаад болохгүй гэж? Орхууд бид хоёрыг өлсгөж алахаа шахсан. Бүсээ л чангалаад байлаа шүү дээ. Цадталаа идээгүй олон хоносон шүү - гэж Пин гомдоллов.

- Өлссөн юм биз дээ хөөрхий, царайг чинь харахад тийм шинж алга л байна даа — гэж Арагорн хэлэв.

- Ярих юм алга - хэмээн Гимли гүүрүүшиг пиво ганцхан хөнтөрч хоослоод хоббитуудыг сонжин харж:

- Үс нь хүртэл өмнөхөөсөө өтгөн, буржгар болсон байна. Бас арай өндөр болчихож, тагжийсан жаахан амьтад байсан шиг санах юм. Өсдөг нас нь өнгөрсөн л баймаар юм. Тэр Модон та хоёрыг өлсгөөгүй л байна даа!

- Байхгүй юм байхгүй л байсан - гэж Мерри хүлээн зөвшөөрөв: - Онтууд зөвхөн умдаагаа л уудаг, гэтэл бид чинь хааяа ч гэсэн юм зажилмаар санагдана шүү дээ. Путлиб хүртэл дуусчихсан.

- Аа, та хоёр онтуудын булагнаас ханатлаа хүртсэн байна шүү дээ, тэгвэл бүх юм ойлгомжтой, Гимли чи зөв харсан байна. Фангорны гайхамшигт булгуудын тухай манай дуунд гардаг юм – Леголас хэлэв.

- Би ч гэсэн тэр хязгаарын талаар хачирхалтай зүйл олныг сонссон. Харин очиж үзээгүй, тэгэхээр эхлээд онтуудын тухай ярьж өг! – гэж Арагорн гуйв.

- Онтууд, тэд нар... – гэж Пин яриагаа эхэлснээ түгдэрч: - Тэд өөр өөр. Харин бүгдийнх нь нүд ... ер бусын гайхамшигтай! – гээд үг олохгүй гараараа дохиод: - Яриад байх юм байхгүй дээ, та нар тэднийг алсаас ч гэсэн харсан, тэд та нарыг бүр өмнө хараад наашаа ирж явааг чинь хэлсэн. Өөрсдөө тэднийг зөндөө харна, тэгээд л ойлгоно биз.

- Байз байз, юу ч ойлгогдохгүй юм яриад л. Бүх юм урвуугаар эргэсэн тэр гайтай өдрөөс эхэлж ярь – гэж Гимли хэлэв.

- Цаг байгаа юм бол эхнээс нь ярьж болно оо, харин та нар идэж ууж ханасан бол нэг сайхан тамхилчихъя. Тэгээд Уулын сууринд, бүр Уудам хөндийд амьд мэнд оччихсон байна гэж төсөөлөөд үзье – гэж Мерри өгүүлээд зузаан гэгч савхин хүүдийтэй тамхиа гаргав.

- Тамхи бидэнд хангалттай бий, сайхан зантай байгаа дээр минь халааснуудаа түнтийлгэцгээ. Өнөө өглөө ийм их олз олсон юм. Үерийн усанд юу эс хөвж явсан гэх вэ! Пин хоёр торх дэгээдэж авсан. Аль нэг хонгилоос л урсч ирсэн биз. Бид хоёр торхыг нээгээд үзсэн чинь огт хороогүй дээд зэргийн тамхи гардаг байна шүү.

Гимли алган дээрээ жаахан тамхи үйрүүлээд үнэрлэж үзсэнээ:

- Дажгүй үнэртэй юм байна, ширхэг нь ч муугүй шүү.

- Юуны чинь муугүй гэж, сайны сайн тамхи даа! – гэж Мерри түүн рүү зэмлэнгүй хараад: - Гимли, найз минь, энэ чинь Уртсүүлтийн тамхи шүү! Торхон дээр нь Аянга Ниргэгчийн тамга байсан гээд л бодчих. Харин энд яаж ирснийг нь би бодоод олохгүй байгаа юм. Саруман л өөрөө татах гэж авчруулсан байх. Манай барааг ертөнцийн хязгаарт хүртэл тээдэг байна шүү дээ. Таалагдаж байна уу?

- Таалагдах л байсан, даанч гаанс минь алга, би гаансаа Мориид юм уу, бүр тэрнээс өмнө ч гэсэн байх. Та хоёр гаанс хүртэл уснаас дэгээдсэн юм биш биз?

- Арай ч үгүй ээ. Агуулахад нэг ч гаанс байгаагүй. Саруман тамхиа торгон цэрэгтэйгээ хуваалцахыг хүсээгүй юм шиг байна. Гэхдээ Ортханк руу гүйж очоод тэрнээс гаансаа түр зээлээч гэж асууж болох л юм. Тэгэх хэрэггүй гэж бодож байна. Нөхөрлөвөл нөхөрлөсөн шиг нөхөрлөх хэрэгтэй, дундаа нэг гаансаараа болгочихъё - гэж Мерри хэлэв.

- Дараачийн удаа! – гэж Пин хэлээд өврөө суйлж, боолттой хавтага гаргаж ирэв:

- Бөгж чирч явдаг хоббит байдаг л юм биз, надад өөр эрдэнэ бий. Жишээ нь миний хуучин чавганы модон гаанс байна. Энийг хараач, нэг ч удаа хэрэглээгүй шинэ гаанс ч байна! Яах гэж би үүнийг авч явдгаа өөрөө ч мэддэггүй юм. Тамхи минь дуусахаар надад бурхан тамхи хайрлана гэж бодоогүй юм даг. Тэгтэл хэрэг болдог л юм байна – гээд тэр Гимлид өргөн хавтгай соруултай гаансаа өгөв:

- Ингээд бид хоёр хуурай ах дүүс болох юм биш биз?

- Мөн ярив аа, хуурай гэнэ шүү! - гэж Гимли дуу алдаад: - Хамгийн их буянтан хоббит минь, би чамд үүрдийн өртэй боллоо!

- Та нар яана ийнэ дураараа л бол, харин би агаарт гарлаа. Тэнгэрийн дор зогсоод салхи үнэртье - гээд Леголас босов.

- Бид ч гэсэн гарна - гэж Арагорн дэмжлээ.

Тэд хаалганы дэргэдэх чулуун сандал дээр суулаа. Үелсэн манан хөөрч, салхинд туугдан хөндий ил гарч ирлээ.

- Нээрэн хэдүүлээ жаахан амарч авъя байз, балгасан дотор суугаад эрхэм хүндэт Гэндальфыг ирэхээс өмнө өөрийнх нь хэлдгээр жаахан чалчъя. Би үнэхээр их ядарсан байна, хэзээ ингэж ядарч байснаа санахгүй байна – гээд Арагорн хэвнэгээрээ хучаад урт хөлөө жийн, амнаасаа цэнхэр утаа савсуулав.

- Нүдэндээ ч итгэмээргүй юм, Тэнэмэл Мөрч гэнэт гарч ирээд утаа савсуулж гарлаа – хэмээн Пин гараа алдлан гайхав.

- Би хаашаа ч алга болоогүй, би тэнэмэл, Дунадан, Гондорын дайчин, умардын мөрч хэвээрээ байна.

Тэд нэг хэсэг чимээгүй тамхилав. Өрнө зүгийн өдлөг үүлний цаанаас нарны туяа ташуухан тусч тэднийг гийгүүллээ. Леголас нар, гэрэлт тэнгэр рүү ширтэн, амандаа нэг дуу аялан хэвгэв. Тэгснээ гэнэт босч суугаад нөхдөө тойруулж харснаа:

- За за, хэвгэж амарлаа! Цаг удаан ч гэсэн тууштай урагшилж байна. Манан сарнилаа, тэнгэр цэлмэлээ, харин хачин хүмүүс та нар өөрсдийгөө утаад л байх юм. Алив нөгөө амласан яриа чинь хаа байна?

- Миний яриа харанхуйд, орхуудын дунд, гар хөл хүлээстэй байснаас л эхэлнэ дээ, байз өнөөдөр хэдэн билээ? – гэж Пин асуув.

- Хоббитуудын тооллоор бол гуравдугаар сарын таван – гэж Арагорн хариулав.

Пин хуруу даран тоолж үзээд:

- Ердөө л ес хоног өнгөрсөн байна шүү дээ! Гэтэл бид салснаас хойш жил болсон юм шиг л санагдаж байна. Хар дарсан зүүд шиг тэр гурав хоногийг эргэж санахад хэцүү байна. Ямар нэг юм мартчихвал Мерри сануулаад өгнө, гэхдээ би товчхон ярина шүү. Өмхий самхай үнэр, ташуур энээ тэрээг санахыг ч хүсэхгүй байна.

Тэгээд тэр Боромирын сүүлчийн тулаан, Дайсны хөндийгөөс Ой хүртэл явсан тухайгаа ярилаа. Түүний яриа сонсогчдын таамагтай таарах үес тэд толгой дохин сонсов.

- Та хоёр зарим нэг эрдэнэсээ замд гээсэн байна лээ, гэхдээ алдаагүйдээ баярла! – гээд Арагорн бүснээсээ хуйтай хоёр кинжаал тайлж өгөв.

- Эцэг минь! - хэмээн Мерри дуу алдаж: - Дахиад харна гэж ёстой бодоогүй шүү! Би илдээ бага зэрэг цус болгож амжсан, гэвч дараа нь Углук бид хоёрын илдийг гартай минь тасдаад авчихаа шахсан. Тэр яаж шүдээ хавирч байсан гээ! Одоо л хүү татна даа гэж бодсон чинь тэр илдийг минь галтай нүүрс шиг л шидэж орхисон.

- Май Пин, чиний товч, би чамд хадгалж ирсэн, үнэлж баршгүй эд шүү дээ - гэж Арагорн хэлэв.

- Би ёстой шүд зууж байж л энэ товчоо орхисон, гэвч өөр яах ч байлаа даа?

- Чи зөв юм хийсэн, эрдэнэсээсээ салж чадахгүй хүнд эрдэнэс нь дараа болдог юм.

- Гараа яаж суллах ухаан сийлсэн чинь үнэхээр гайхамшигтай! - гэж

Гимли хэлээд: - Аз тохиож, гэхдээ аз таарах болгонд амиа авраад гарч тэр бүрийд чадахгүйшүү дээ.

- Авраад гарах нь ч гарч, харин мөр нь хаашаа алга болчихдог юм бэ? Та хоёрт далавч ургасан байх гэж л бодлоо шүү дээ – гэж Леголас хэлэв.

- Үгүй ээ, далавч ургаагүй, харин Грышнакийн хийсэн ажил – гэж Пин хэлснээ бие нь агзасхийн огиулав. Тэгээд дуугүй болоход хамгийн аймшигтай хэсгийг нь Мерри гүйцээж ярилаа.

- Барад-Дураас ирсэн орхууд надад тун ч таалагдахгүй байна, хар эзэн болоод тэрний гар хөл бологсод дэндүү их юм мэдэж байсан, гэтэл бас тэр Грышнак изенгардынхантай цуст тулаан хийсэн тухайгаа мөрний цаанаас мэдээлэх гэж самбаачилжээ. Одоо хар эзэн Изенгардыг галт нүдээрээ өрөмдөж байгаа. Саруман урхинд орсон байна, хэлэх юм алга – гэж Арагорн бодлогоширонгуй өгүүлэв.

- Хэн ч яллаа гэсэн Саруман хэцүүднэ, тэрний орхууд Ристанид шургаснаас хойш хамаг юм нь буруугаар эргэсэн – гэж Мерри хэлэв.

- Бид тэр хөгшин луйварчинг нүдний булангаар харсан, хэрэв Гэндальф үнэн хэлсэн бол тэр мөн дөө, Фангорны ойн захад - гэж Гимли хэлэв

- Хэзээ харсан бэ? – гэж Пин асуув.

- Тав хоногийн өмнө.

- Байз байз, тав хоногийн өмнө гэдэг чинь та нар эхнээс нь аваад эцсийг нь хүртэл мэдэхгүй тэр үйл явдал эхэлсэн өдөр байна шүү дээ - гэж Мерри хэлээд: - Бид хоёр тулалдааны маргааш өглөө Модонтой тааралдаж, түүний нэг өргөөнд очсон юм, Булагт гэдэг юм. Өглөө нь бид онтуудын хуралдайд очсон, тийм сонин юм би амьдралдаа үзээгүй, үзэх ч үгүй биз. Хуралдай гурван өдөр үргэлжилсэн, бид хоёр Хурдан гэдэг онтынд хоносон. Гурав дахь өдөртөө тэд шийдвэрээ гаргасан, тэгээд л оволзож гарсан даа. Ой аянга хуримтлуулж байгаа юм шиг нам гүм болсноо дараа нь ёстой аянга ниргэсэн. Та нар тэдний аян дайны дууг сонссон ч болоосой!

- Саруман сонссон бол зуун бээр газар эргэж ч харахгүй зугтах байсан - гэж Пин хэлэв.

- Их урт дуу байсан. Сүүлдээ үг ч байхгүй, бүрээдэж байгаа юм шиг хүнгэнээд л, бөмбөр нижигнээд л. Би тэднийг зүгээр л шуугилдаж байна гэж эхэндээ бодсон. Гэтэл тэд зүгээр нэг шуугилддаггүй гэдгийг ойлгосон.

- Харанхуй болж байхад бид Нан-Курунирын дэвсэг дээр гарсан, тэгэхэд бидний араас ой өөрөө явж байгаа юм шиг надад анх санагдсан юм. Би унтчихаад онтын зүүд зүүдэлж байна даа гэж бодсон. Гэтэл үгүй байсан, Пин ч бас тиймэрхүү юм харжээ. Бид хоёр айж байсан ч юу болоод байгааг ойлгоогүй. Гэтэл тэд бол ярихайнууд байсан юм билээ. Онтууд “товчхон хэл”-ээрээ тэгж нэрлэдэг юм. Модон тэдний тухай бид хоёрт цухас дурсч байсан юм. Адилхан л онтууд боловч гаднаас нь харахад модожсон онтууд. Тэд газар сайгүй, ойд, ойн захад зогсч байдаг, ой модыг чимээгүйхэн манаж байдаг юм. Ойн гүнд хэдэн зуугаараа байдаг гэсэн. Тэдний хүч нь нууц бөгөөд аймшигтай, өөрийгөө тойруулаад манан үүсгэдэг, явж байгаа нь бараг анзаарагдахгүй. Гэтэл айхтар хурдан явдаг, уурлахаараа бүр ч хурдан. Жишээ нь, модгүй газар зогсоод цаг агаарын байдлыг ажиглаж, салхины сэрчигнээг сонсч байтал гэнэт эргэн тойронд ой мод хүрээлж, аварга том модод үндэс, мөчрөө өөдөөс чинь сарвайж байна. Тэд хэл яриагаа хадгалж үлдсэн, онтуудтай ярьдаг, тэгээд л ярихайнууд гэж нэрлэдэг юм. Гэвч Модонгийн хэлснээр бол сүүлдээ зэрлэгшсэн юм байна. Жинхэнэ онттой л хамт явахгүй бол Фангорны ойд тэдэнтэй тааралдсаны хэрэггүй.

Тэгээд бид Илбийн хонхорын хойт ууланд шөнө дунд хүртэл нуугдсан, Онтууд, тэдний араас үй олон ярихайнууд. Бид хоёр тэднийг харж чадаагүй боловч чихарч, шажигнахыг нь сонсч байлаа. Бүрхэг, харанхуй шөнө байсан. Тэд уулнаас ой мод тэр чигээрээ ханарах мэт буухад, чихэнд салхи исгэрч байлаа. Үүлний цаанаас сар шагайдаг ч үгүй, шөнийн нэг цагт Изенгардын хойт талаас балар өтгөн ой бууж ирсэн. Эргэн тойронд хэн ч байхгүй. Зөвхөн цайзын дээрх цонхнууд л гэрэлтэж байлаа. Модон нөхдийнхөө хамт том хаалганд дөхөж очиход Пин бид хоёр Модонгийн мөрөн дээр сууж байсан, түүний бие хэрхэн хөвчирч байгааг би мэдэрсэн. Онтууд хичнээн их догдолж байсан ч маш их болгоомжтой, тэвчээртэй. Тэд хөшөө мэт хөдөлгөөнгүй зогсоод, чив чимээгүй сонсч байв. Гэнэт эргэн тойронд нижигнэсэн их чимээ гарав. Яндангууд улих мэт орилж, Изенгардын ханануудаар цуурай нүргэллээ. Биднийг харчихаж, одоо байлдаан эхэлнэ гэж бид хоёр бодов. Гэтэл Саруман хамаг цэргээ цайзаас гаргасан ажээ. Би дайны тухай тун бага юм мэднэ. Энэ дайн ч бай, өөр бусад дайн ч

бай ялгаагүй, Ристанийн морьт дайчдын талаар юу ч мэдэхгүй. Гэвч нэг юм тодорхой байсан нь Саруман ганцхан дайралтаар эзэн захирагч болон түүний дайчдыг нэгмөсөн зүйл дуусгахаар төлөвлөжээ. Изенгардыг хэнээс хамгаалах вэ? Дайснууд яаж явж байгааг би харсан. Шоргоолж шиг шороон түмэн орхууд хар хуяг дуулгатай, асар том чоно унасан орхууд ч үй түмээрээ, тэдний араас хүмүүс, бас л замбараагүй олон, бамбарын гэрэлд тэдний нүүр царай харагдаж байсан. Хүмүүс шиг л хүмүүс, өндөр, бараан үстэй, баргар царайтай. Тэд аймаар муухай харагдаагүй, харин өөр амьтад – хүний хэрийн өндөр мөртөө нүүр царай нь баримал шиг шар саарал, сөлөр нүдтэй. Уулын сууринд тааралдсан өмнөдийн нэг этгээд надад санагдсан, гэхдээ тэр бол орх гэхээс хүнтэй илүү төстэй байсан.

- Тийм ээ, би ч гэсэн тэрнийг санаж байна, бид Хельмагийн хавцалд тийм хагас орхуудыг харахаараа нэг болсон. Тэгэхлээр тэр өмнөдийн этгээд Саруманы тагнуул байсан юм байна, гэхдээ тэр хар морьтнуудтай сүлбэлдсэн үү, эндхийн эзэндээ үнэнч байсан уу, бүү мэд. Тэгээд ч тэр хар муу үйлтнүүд хэзээ үнэнчээр зүтгэж, хэзээ хуурч мэхэлж, луйвардахыг хэн мэдлээ – гэж Арагорн хэлэв.

- Товчоор хэлэхэд Саруманы арми багаар бодоход хэдэн зуун мянган цэрэгтэй байсан. Тэд шөнийн нэг цагийн орчимд хаалгаар гарч ирсэн. Нэг хэсэг нь гарам руу, бусад нь шууд зүүн зүг рүү явсан. Эндээс нэг бээр орчим зайтай, гол чулуун голдрил руу гүн орсон газарт нэг гүүр байсан, одоо тэр гүүрнээс үлдсэн юм нь тээр тэнд харагдаж байна. Тэд сөөнгө хоолойгоор дуулж байгаа бололтой орилолдож, хөхрөлдөж байсан. Ристаничууд ч хэцүүдлээ дээ гэж би бодлоо. Харин Модон тэднийг огтхон ч хэрэгсээгүй. “Одоо тэдэнтэй орооцолдох цаг алга. Би Изенгардын хад чулуу, хана хэрэмтэй ноцолдоно” гэж хэлсэн – гэж Мерри ярив:

- Тас харанхуйд орчны юмс үзэгдэхгүй байсан ч хэрмийн хаалга хаагдангуут ярихайнууд өмнө зүг рүү хөдөлж байх шиг санагдав. Тэд орхуудтай тооцоо бодохоор явсан байж таарна. Өглөө болоход тэд хөндийд гүн орсон. Тэртээ алсад бараан толбо шиг юм харагдаж байсан. Саруманы арми холдонгуут бидний ажил эхэлсэн дээ. Модон биднийг газарт хэвтүүлээд өөрөө хаалган дээр очиж Саруманыг дуудан хаалгыг балбаж гарлаа. Хэрэм дээрээс сум, чулуун мөндөр бууж эхлэв. Онтуудыг сум яах ч үгүй: шумуул хазахын дайтай юм ч болохгүй. Онтуудыг сумаар зайгүй шивсэн ч тэд бараг анзаарахгүй. Тэднийг хор дийлэхгүй, арьс нь модны холтосноос ч зузаан. Хурц сүхээр хамаг чадлаараа цавчвал өөр хэрэг, тийм учраас тэд сүхийг үзэж чаддаггүй юм. Гэхдээ нэг онтыг цавчихад олон түлээчин шаардлагатай, онтыг нэг цавчвал түлээчин өөрөө амиа алдах нь гарцаагүй. Онтын нударга ямар ч хуяг, бамбайг бяслаг шиг л зүснэ.

За тэгээд дайснууд Модон руу харваад л байлаа, Модон уурлаж “яарахаар” шийдэв. Тэр уурлахыгаа ингэж нэрлэдэг юм. “Хрру-ум - ху-ум” – гээд л ганц хашгирсан чинь арав гаруй онт туслахаар очлоо. Уурласан онт бол тоглоом биш. Тэд гар хөлийнхөө хуруунуудаар хад чулууг хатсан талх шиг л хамхалж орхино. Модны үндэс хад чулууг зуун жилд яаж дийлдэг билээ, бидний нүдний өмнө тийм л юм болсон доо. Тэд хаалгыг ганхуулж, нурааж, хагалж, буталсаар таван минутын дотор аварга том хаалгыг зүйл дуусгаад, хэрмийн ханыг зүгээр л молтогчингууд элс ухаж байгаа юм шиг нүхэлж, нурааж орхив.

Саруман юу гэж бодсоныг бүү мэд, ямар аюул толгой дээр нь бууж байгааг ойлгосон уу, үгүй юу, ямар ч л гэсэн ямар ч хариу хийж чадаагүй. Тэр шидтэн одоо тун тааруухан байгаа, ид

шид нь ч алга болсон биз. Ер нь хариугүй муу хулчгар, зүрх зориг ороход нь тэрэнд хүзүүвчтэй боолууд, хэлхээстэй дугуйнууд хэрэгтэй. Гэндальфын дэргэд тэр юу ч биш. Саруман Изенгардад бүгээд бүгдийг мэхэлж, айлгаж байсан учраас л алдаршсан байх.

- Тийм ч үгүй шүү - гэж Арагорн хэлээд: - Нэгэн цагт тэр алдар цуугаа өөрийн чадлаар авсан юм. Түүний эрдэм нь агуу, ухаан нь хүчирхэг, гар нь гайхалтай уран, хамгийн гол нь бусдын ухааныг эзэмдэж чаддаг байсан юм. Мэргэдийг ятгаж чаддаг, тэнэгүүдийг айлгаж чаддаг байсан. Тэр одоо ч гэсэн энэ чадлаа алдаагүй байгаа. Дундад газар даяарт Сарумантай ярилцсанахаа дараа өөрийн бодлоо хадгалж үлдээд, түүнийг эрхэндээ оруулах мэргэд хуруу дарам цөөхөн. Одоо ялагдчихаад байхдаа ч гэсэн. Гэндальф, Элронд, Галадриэль, өөр хэн байгааг мэдэхгүй, түүний илбэ, муу үйл нь илэрхий бөгөөд эргэлзээгүй байгаа нь харамсалтай.

- Онтууд тэрэнд дийлдэхгүй ээ, тэр нэг удаа мэхэлж дөнгөсөн, дахиад чадахгүй. Тэгээд ч тэдний тухай бага мэддэг учраас тэднийг тооцооноос хасч маш том алдлаа. Тэрний төлөвлөгөөнд онтууд байгаагүй, одоо тэд өөрсдөө хөдөлсөн болохоор төлөвлөгөөндөө оруулах оройтсон. Нэг үгээр хэлэхэд онтууд дэндүү аймшигтай довтолсон учир Изенгардын гарнизоны үлдэгдэл харсан зүг рүүгээ тонилж, харх шиг нүх сүв болгоноор шургаад алга болсон. Хүмүүсийг нь онтууд барьж, асууж байцаагаад суллаж явуулсан. Хорь гучаас хэтрэхгүй хүмүүс үлдсэн байна лээ. Харин том, бага орхууд амьд гараагүй байх. Онтууд өршөөлөө ч гэсэн ярихайнууд үлдээхгүй – гэж Пин ярив:

Тэгээд онтууд өмнөд ханыг нурааж хэмхэлж байхад гарнизон нь ор мөргүй алга болсон, гэтэл Саруман өөрөө хаа нэгтгээгээс гараад ирлээ. Тэр нүсэр армия үдэж гаргаад хаалганы орчимд байсан ажээ. Эхлээд тэр чадамгай нуугдсан учир онтууд олж хараагүй. Гэвч үүл хөөгдөж, од гэрэлтэхэд онтуудын хувьд нартай өдөр шиг гэрэлтэй болсон хэрэг, гэнэт Хурдан “Модны алуурчин, модны алуурчин!” – хэмээн хашгирах сонсогдов. Дөлгөөн, эелдэг зантай Хурдан Саруманыг аймшигтай ихээр үзэн яддаг юм. Түүний хамгийн хайртай улааганы төглийг орхууд оргүй болтол цавчиж хаясан гэсэн. Тэр дотоод хаалганы дэргэдэх ханан дээрээс үсрэн буугаад Ортханкийн замаар хурдалсан. Хэрэгтэй цагт тэд салхинаас ч хурдан болдог. Нэгэн саарал дүрс баганаас багана руу дамжин гүйсээр цамхгийн шатанд хүрсэн. Нэг л хором алдсан бол Хурдан тэрнийг хаалганы дэргэд барьж аваад багалзуурдаж орхих байв. Саруман Ортханк руу оронгуутаа элдвийн хачин машинуудаа бүгдийг бүх хүчээр нь ажиллуулсан. Изенгардад хангалттай олон онтууд цугларсан байлаа. Заримыг нь Хурдан дуудаж ирүүлсэн, бусад нь зүүн ба хойт ханыг цөмлөөд орж ирсэн байв. Гэнэт цооногууд, уурхайнуудаас өмхий гал утаа олгойдлоо. Онтуудын зарим нь түлэгдэж гэмтэн, зарим нь шатсан. Буко гэдэг өндөр чилгэр онт шингэн галын тургианд оногдож бамбар шиг дүрэлзэн шатсан.

Тэгэхэд онтууд ёстой галзууртлаа хилэгнэсэн. Тэд бүрээ мэт хүнгэнэн нижигнэлдэж, зөвхөн тэр чимээнд нь хана хэрэм аяндаа нурж байлаа. Мерри бид хоёр нэг завсар руу лавхан орж аваад чихээ дараад суучихсан. Изенгардад шуурган түймэр ороод ирэх шиг л болсон. Онтууд багануудыг сугалан авч, уурхайнуудыг чулуу, хайргаар дарж, эргэн тойронд хадан хясаа, хана хэрэмнүүдийн хэлтэрхий хуй салхинд хөөрсөн навчис мэт хийсч байлаа. Тэр аймаар шуурган дунд Ортханкийн цамхаг автагдашгүй цайз адил сүндэрлэж байв. Хэдэн зуун фут өндөрт хөөрсөн хад чулуу, төмөр тэрэнд ямар ч хохирол хүргээгүй.

Аз болоход Модон эрүүл ухаанаа алдаагүй байсан. Ер нь түлэгдэж шархдаа ч үгүй байсан. Онтууд уур хилэндээ авган өөрсдийгөө хөнөөж мэдэхээр болсон байв. Тэр хооронд Саруман аль нэг нууц нүхээр шургаад алга болох байсан. Онтууд хэрмээр давж байсан шигээ хурдаа авч байгаад гялгар хар цамхаг руу үсэрч байлаа. Тэгэхэд Саруманы ид шид үйлчилсэн гэж би бодож байна. Цамхагт онтууд ан цав ч гаргаж чадалгүй, өөрсдөө гэмтэж шархдаж байв.

Тэгтэл Модон хэрэмний цаана гараад тэр аймшигт чимээ шуугианыг дартал чанга бүрээдэв. Эргэн тойронд амьдралгүй мэт нам гүм болж, цамхгийн дээд цонхноос хорсож занасан, зүрх зүсэм зэвүүн чанга инээд сонсогдов. Тэр инээд онтуудад гайхалтай нөлөөлсөн. Дөнгөж сая уур хилэндээ авгаж, ертөнц дээр юу ч үлдээхгүй гэсэн мэт нурааж, хэмхэлж байсан тэд хоромхон зуурт дүнсгэр, хүйтэн, тайван болсон байв. Тэд Модонг тойрон цугларахад Модон тэдэнд нэг юм намуухан ярьж, цаадуул нь хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй сонсч байв. Тэр өөрийнхөө хэлээр ярьсан боловч би түүнийг өөрийнхөө төлөвлөгөөг тайлбарлаж байна гэж ойлголоо. Тэр төлөвлөгөө нь урьдаас бэлтгэсэн, магадгүй бүр аль эрт бодож боловсруулсан ч байж мэднэ. Дараа нь тэд үүрийн өмнөх саарал харанхуйд уусах мэт алга болов.

Цамхгаас тэд нүд салгаагүй нь мэдээж, тагнуулууд хаа нэгтээх харанхуй газраас ажиглаж байсан. Бусад нь бүгд хойт зүг рүү усанд унасан чулуу мэт алга болоход бид хоёр хоёулхнаа үлдэв. Уйтгартай бүрхэг өдөр болж, бид хоёр үүгээр түүгээр тэнэж, Ортханкийн бүхнийг харагч хорсолт нүднүүдээс чадахын хэрээр нуугдаж явлаа. Бид хоёр идчихмээр юм хайсан боловч юу ч олсонгүй, аргаа бараад нэг нууцхан газар суугаад өлсч байгаагаар мартагчдын тулд өмнө зүг, Ристанид ямар тулалдаан болж байгаа бол, хөөрхий бөгж хадгалагч хоёр яаж яваа бол доо гэсэн шүү юм ярьж байв. Байн байн бүдэгхэн нижигнэх чимээ гарч, их л нүсэр том юмс нуран унаж байгаа чимээ уулс дамжин цуурайлж байлаа.

Орой болоход бид хоёр хаана юу болоод байгааг харахаар гарлаа. Хөндийн нэг талд ярихайнууд баргар ой болон дүнсийж, нөгөө талаас бас нэг ой Изенгардын цайз руу баруун хойт талаас ойртож байна. Бид хоёр ойртож зүрхэлсэнгүй, зөвхөн алсаас чимээ чагнаж байв. Онтууд болон ярихай нар суваг шуудуу, цөөрөм, усан сан ухаж, далан барьж байлаа. Тэд Изен гол, ойр хавийн бүх горхи булаг, жижиг голуудаас ус цуглуулж байгаа нь илт байлаа. Бид хоёр тэдэнд дараа болохгүйг хичээн ажиглаж байв.

Бүрэнхий болох үеэр Модон хаалган дээр хүрч ирэв. Тэр их л сэтгэл хангалуун бололтой хүнгэнэж дүнгэнэж байлаа. Уртын урт гараа алдлан суниаж, хөлөө сэгсрэн амрааж, урт уртаас амьсгална. Их ядрал уу гэж би түүнээс асуулаа.

“Ядрах гэнэ ээ? – гэж тэр асуугаад: - Би ядарна гэж үү? үгүй дээ, харин жаахан хуурайшсан байж магадгүй. Яг одоо Онтавын уснаас уух юмсан. Харин их ажил бүтээлээ. Хад чулуу нурааж энэ хавийн газрыг зуу гаруй жилийн өмнөх шиг болголоо. Гэхдээ хийх ажлаа хийчихлээ гэж бод. Та хоёр шөнө болохоор хаалганаас... юу гэдэг билээ дээ... хонгилоос холхон байгаарай! Тэндээс эхлээд өмхий самхай үнэртэй, бохир заваан ус олгойдно, Саруманы хамаг муу муухайг угаасны дараа Изений цэвэр цэнгэг ус оргилно – гэлээ. Тэр хэсэг амарч зогсохдоо хэрмийн ханыг зугаацах маягаар ухаж зуун футын хэмжээний том том хэлтэрхийнүүд унагалаа.

Бид хоёр арай тайван унтчихмаар газар хайж эхэлтэл жинхэнэ гайхмаар юм болох нь тэр.

Морин төвөргөөн сонсогдож, нэгэн морьтон замаар хурдалж айсуу. Мерри бид хоёр ч хэвтээд өглөө, Модон нуман хаалганы доорх харанхуйд нуугдлаа. Мөнгөлөг өнгөөр гялалзсан аварга том морь дүүлэн гарч ирэхэд харанхуй байсан ч гэсэн би морьтны царайг сайн харсан. Түүний царай гэрэлтэж байсан, бас цав цагаан өмсгөлтэй байв. Би өндийж суугаад түүн рүү амаа ангайн ширэв. Дуудах гэсэн чинь дуу гардаггүй.

Гэвч дуудах хэрэгцээ гарсангүй. Тэр бидний дэргэд ирээд харж байна. “Гэндальф!” – гэж эцсийн эцэст би арайхийн шивнэв. Тэр “Хүүе ээ, сайн уу Пин! Ямар сайхан учрал гээч вэ!” – гэж хэлсэн гэж та нар бодож байна уу? Харин ч үгүй шүү! Тэр ердөө л “Бос, залхуу Молтогчин! Аянга та нарыг ниргээсэй. Энэ холион бантан дотор чинь Модон хаашаа алга болчихов? Тэр надад яг одоо хэрэгтэй байна. Олоод ир, түргэл!” – гэж зандарсан юм шүү.

Модон түүний дууг сонсоод харанхуйгаас гараад ирлээ. Ёстой жинхэнэ уулзалт л тэр байсан! Гол нь би тэгж их гайхаж байхад тэр хоёр юу ч болоогүй юм шиг. Гэндальф Модонг яг энд л байгаа гэж давхиж ирсэн, цаадах нь түүнийг угтахын тулд л энэ хаалганы хавьд хүлээж байж л дээ. Гэтэл би Модонд Морийн тухай болоод өөр зөндөө юм чалчсан, тэгэхэд тэр над руу нэг л хачин харсныг санаж байна. Тэгэхээр Модон Гэндальфтай уулзсан юм уу, түүний тухай сонссон юм байна гэж би бодсон. Тэр юуны өмнө “Яарах хэрэггүй, яарвал ялааны инээд хүргэнэ” гэсэн зарчимтай, гэвч яарсан ч, яараагүй ч эльфүүд хүртэл Гэндальфыг гүйцдэггүй биз дээ.

“Кгум! чи юу Гэндальф! – гэж Модон асуугаад: - “Чи яг цагаа олж ирлээ. Ус, мод, чулуу, хадан хясаа бүгд миний эрхэнд, гэтэл шидтэн хүрээд ирлээ, би юу хийхээ мэдэхгүй байна” -гэлээ.

“За Модон минь, надад чиний тусламж хэрэгтэй байна. Чи маш их юм хийлээ, гэвч энэ чинь бага байна. Би зуугаад мянган орхын учрыг олмоор байна” – гэж Гэндальф хэлэв.

Тэгээд тэр хоёр зөв шийдвэр гаргахын тулд зөвлөлдөхөөр хаа нэг тийшээ явсан, Модон яарах дургүй ч гэсэн Гэндальф үнэхээр их яарч байсан нь илт байсан тул хэдхэн минутын дараа Гэндальф эргэж ирэхэд санаа нь амарсан шинжтэй байлаа. Тэр ч байтугай хөгжилтэй болж, бид хоёртой уулзсандаа баяртай байна гэсэн.

“Сонсооч, Гэндальф, чи ер нь хаана байсан юм бэ? Манай хэдтэй уулзсан уу?” – гэж намайг яаран асуухад:

“Би байсан газраа байж байдаггүй, манай хэдийн хэн нэгтэй нь уулзсан. Гэвч одоо мэдээлэл солилцохоо азная. Аюултай шөнө болно, сатаарч болохгүй, би дахиад зөндөө давхих хэрэгтэй байна. Харин маргааш өглөө гэрэл гэгээ гийвэл уулзаж ярилцана. Амь биеэ сайн хамгаалж ортханкаас аль болохоор холхон байгаарай, баяртай” – гэхичээд л давхичихсан. Модон түүний араас их бодлогошронгуй харж байсан. Тэр уулзаад салах зуурт их юм мэдэж авсан, тэр тухайгаа бодож байгаа нь илт байлаа. Тэгээд бид хоёрт хандаж: “Хм, та нар чинь тийм ч их яаруу улс биш байна шүү. Ярьж чадахаасаа хамаагүй бага ярилаа, гэхдээ яг ярих хэрэгтэйг л ярилаа. Тийм ээ, бөөн бөөн мэдээ авлаа, тэднээс хаашаа зайлах билээ! Модон минь, чамд дахиад зөндөө их ажил байна!” –гэлээ.

Бид хоёр түүнээс бага сага мэдээ чангааж амжсан, сонссон мэдээндээ баярлаагүй. Та гурваас

болж л санаа зовсон хэрэг шүү дээ. Та гурвыг агуу том тулалдаан хүлээж байгаа, амьд гарах эсэхийг чинь яаж мэдэх билээ. Фродо, Сэм, хөөрхий Боромирын тухай бодохоо ч мартчихсан.

“Ярихайнууд тусална” – гэж Модон хэлчихээд яваад өгсөн, тэгээд өнөө өглөө л ирж байна.

- Хэцүү шөнө байсан даа – хэмээн Пиний яриаг Мерри үргэлжлүүлж: - Бид хоёр өндөр овоорсон чулуун дээр яаж ийгээд байрласан, эргэн тойрон утаа манан. Уур манарч, шаржигнах, тачигнах чимээ, хүнгэнэсэн удаан аялга холдож байгаа нь сонсогдож байв. Хэдэн зуун ярихайнууд нөхөддөө туслахаар явж байгаа бололтой. Дараа нь өмнө зүгээс аймшигт аянгын дуу дараа дараагаар нижигнэж, Ристанийн дээгүүр аянгын цахилгаан цахилж байсан. Эндхийн уулсаар ч гэсэн аянга нижигнэж, хөндийгөөр дүүрэн цуурайлж байсан, гэхдээ тулааны чимээнээс огт өөр байлаа.

Шөнө дундаас хойш онтууд усан сан, суваг, шуудуу, цөөрмүүдээ нээж, Изенгардыг хойт талд нь гаргасан том нүхнүүдээр хүчит үер оруулан живүүлэв. Ярихайнууд яваад өгсөн, харанхуй манан сарниж, алсад аянгын чимээ намжлаа. Сар баруун нуруу руу тонгойв. Изенгардаар дүүрэн энд тэндгүй үерийн ус уур хилэнтэйеэ оволзож, сарны гэрэлд хар үер аюумшигтай сүрлэг харагдаж байв. Ус Саруманы уурхай, цооногууд руу нүх сүв бүхнээр орж, тэндээс бөөн бөөн уур багсран хөөрч, энд тэндгүй шуугин исгэрэх, пис писхийн дэлбэрэх чимээ гарч, утаа олгойдно. Асар хүчтэй дэлбэрэлтүүд гал утаа оволзуулна. Ортханкийг утаа, уур, гал холилдсон манан могой шиг ороож, доод талаасаа гал улаан, дээд талаасаа ногоон саарал оргил шиг харагдана. Үерийн ус улам хүч нэмэн оволзсоор. Изенгард яг л задгай гал дээр буцалж байгаа шөл шиг буцалж байлаа.

- Өнгөрөгч шөнө Нан-Курунирын зүгээс утаан үүл нүүж байсан юм. Саруман ямар нэг шинэ хар үйл сэдэж дээ гэж бид айж байлаа – хэмээн Арагорн яриаг нь таслав.

- Саруман уу даа! - хэмээн Пин инээж: - Тэр юун шинэ юм сэдэхтэй манатай, өөрийнхөө гал утаанд бүтэж үхэх шахсан биз. Өглөө гэхэд онтуудын ус тэрний бүх нууц уурхай, цооног, нүх сүвийг усаар дүүргэж, өмхий үнэртэй өтгөн манан бүрхсэн байлаа. Бид хоёр тэр харуулын цамхаг руу гүйж ороод хэзээ үерт живдэг юм бол доо гэж айж байлаа. Ус улам л нэмэгдээд, хонгилоор дүүрэн үер. Нэг хамаад авбал тэгээд л дуусах байлаа. Бид хоёр нүхэндээ байгаа орхууд шиг л живлээ гэж бодсон, аз болоход агуулахаас дээш нуман хаалга руу гардаг мушгиа шат олдсон. Тэнд гараад бид хоёр чулуун дээр сууж, Изенгардын их намгийг харж байлаа. Онтууд бүх гал түймрийг унтрааж, газар доорх бүх агуйг усаар дүүргэн цэвэрлэхийн тулд ус нэмсээр л байлаа. Манан улам ихэссээр нэг бээрээс багагүй өндөртэй аварга том мөөг шиг юм боллоо. Орой болоход зүүн нуруун дээгүүр аварга том солонго татсан, дараа нь асар их бохир аадар асгарсан. Ерөнхийдөө нам гүм, хаа нэгтээ алсад чононууд гунигтай улих л сонсогдож байв. Онтууд шөнө үерийг зогсоож, Изенийг хуучин голдрилоор нь урсгасан. Ингээд л бүх юм дууссан даа. Ус ч алга болсон, газар доорх агуйнуудад доод давхар байдаг юм байна. Аль ч цонхоор нь харсан шавар хог новшноос өөр юм байхгүй. Саруманд атаархах юм байхгүй байна лээ. Бид хоёрт ч уйтгартай байлаа. Эргэн тойронд хэн ч байхгүй, онтуудаас ч мэдээ байдаггүй. Бид хоёр бүхэл шөнөжин нуман хаалганы дээр, унтсан ч юм байхгүй, даарч хөрч хоносон. Юу юугүй л нэг юм болох гэж байгаа юм шиг санагдаад байлаа. Саруман цамхаг дотор байгаа шүү дээ! Шөнө шуугианы чимээ сонсогдож, хөндийгөөр салхи хүүгээд байгаа юм шиг байсан. Онтууд, ярихайнууд эргээд ирсэн юм болов уу гэмээр, гэвч юу ч

үзэгдэж харагдаагүй, хаашаа яваад өгснийг мэдэх ч юм байхгүй.

Манантай хүйтэн өглөө бид хоёр доошоо буугаад эргэн тойрноо харахад бас л хэн ч байдаггүй. Ингээд өөр ярих юм алга шив дээ. Нэгэнт Гэндалф ирсэн юм чинь учрыг нь олно биз дээ. Одоо нэг сайхан унтах юмсан!

Хэсэг дуугүй сууцгаав. Гимли тамхи нунтаглаад гаансаа дахин нэрэв.

- Надад нэг юм сонин байна – гээд тэр хэтээ цохиж тамхиа асаагаад нэг сайн сорсноо: - Өмхий Амт. Тэр цамхаг дотор Сарумантай хамт байгаа гэж Теоден хэлсэн. Тэр тийшээ яаж ордог байна аа?

- Өө мартчихаж, хэмээн Пин духаа алгадаад: - Тэр өнөө өглөө энд ирсэн. Бид хоёр дөнгөж гал асаагаад, жаахан юм идэж байтал Модон хүрээд ирэв. Тэр хүнгэнэж, дэвслээд л бид хоёрыг дуудаж байна.

“Аа, хүүхдүүд минь энд байна уу, уйдаагүй биздээ? Та хоёрт дуулгах сонин байна. Ярихайнууд эргээд ирсэн. Тэнд, Ристанид бүх юм дажгүй, бүр муугүй! – гээд инээж, гуяа алгадаад, Изенгардын модны алуурчин орхуудыг зүйл дуусгасан. Бидэн дээр өмнөдөөс зочид ирж явна, одоохон ороод ирнэ. Заримтай нь та хоёр уулзах учиртай байх!” – гэлээ.

Тэр ингэж хэлж дуусав уу, үгүй юу туурайн чимээ гарав. Бид хоёр ч хаалга руу ухасхийлээ. Би Гэндалф, Тэнэмэл хоёрыг ялалт байгуулсан дайчдын магнайд давхиад ирнэ гэж бодоод нүдээ бүлгийтэл харж байтал үгүй шүү! Манан дундаас их хөлөрсөн морьтой, харваас нүдэнд хүйтэн нэг амьтан гараад ирдэг юм байна. Араас нь хэн ч байдаггүй. Тэр манан дундаас гарч ирээд, энд юу болсныг харангуут ангайтлаа гайхаж, нүүр нь ногоорох шиг болсон. Сандарсандаа тэр биднийг ч анзаарах сөхөөгүй байв. Дараа нь биднийг хараад дуу алдан хашгирч, мориныхоо амыг эргүүлэх гэтэл Модон ганцхан харайгаад дэргэд нь хүрч, урт гараараа тэрнийг эмээл дээрээс нь гулд татан буулгав. Морь нь цоройн эргээд манан дундуур давхин одов. Тэр амьтан газарт буулгангуут шууд л элгээрээ газар тэвэрч тэмтрэн мөлхөнгөө, “Би эзэн захирагчийн дэргэдийн зөвлөх Грима байна, намайг Теоден яаралтай мэдээ хүргүүлэхээр Саруман руу илгээсэн юм. Бүгд айгаад явахгүй гэхээр нь би ганцаараа явъя гэсэн юм. Эргэн тойронд орхууд шиншилж байгаа. Аймшиг гэгчийг тууллаа, үхтлээ ядарлаа, бүтэн хоног хэлэн дээрээ юм тавьсангүй. Намайг чононууд хөөсөн, би хойт зүг рүү зугтааж тойруу замаар ирлээ” – гэв.

Тэр Модон руу яаж хялайж байгааг нь хараад би “Зуун хувь худлаа ярьж байна даа” гэж бодлоо. Модон түүн лүү удаан харахад тэр арай л газар руу шигдээд орчихсонгүй. Дараа нь Модон: “Кха, кхм, би чамайг аль түрүүнээс хойш хүлээж байна аа, эрхэм өмхий Амт аа” – гэлээ. Нөгөөдөх чинь бүр ч арчаагаа алдаж, цаашаа юу болохыг л хүлээж байгаа бололтой. Модон хэлэв: “Гэндалф энд ирээд явсан, би чиний талаар бүгдийг мэднэ, тэр байтугай чамайг хааш нь алга хийхээ ч мэднэ. Гэндалф бүх хархнуудыг нэг торонд цуглуул гэж тушаасан. Яарч үз. Одоо Изенгардын эзэн нь би, харин Саруман цамхаг дотор сууж байгаа. Тийм л яаралтай мэдээ хүргэж яваа юм бол тэрэн дээрээ түргэн оч” - гэв.

“Намайг явуулчихаач дээ, явуулчих! Би өөрөө зам мэднэ” – гэж өмхий Амт гуйхад Модон:

“Урьд нь ч чи мэддэг байсан л даа, гэхдээ одоо түүгээр явахад хэцүүхэн л болсон доо. Юу ч гэсэн яваад үзэхгүй юу!” – гэв.

Өмхий Амт нуман хаалган доогуур салгалан ороход бид араас нь дагасан юм. Тэр хонгилыг өнгөрөөд, хэрмийн хана, Ортханк хоёрын хоорондох бохир сувгийг хараад ухарлаа.

“Би буцъя! Нам.... намайг явуулчих! Миний мэдээ хожимдчихож!” – гэж тэр уйлагнав.

“Юу үнэн бэ, тэр үнэн. Гэхдээ чамд сонголт байна. Нэг бол энэ суваг руу ор, эсвэл надтай үлдээд Гэндалф болон чиний эзэн захирагчийг хүлээе. Аль нь чамд таалагдаж байна?” – гэсэн чинь тэр эзэн захирагч гэнгүүт чичрэн суваг руу ухасхийсэн боловч зүрхэлсэнгүй ухрав.

“Би сэлж чадахгүй!” – гэж тэр гаслав.

“Тэнд гүнзгий биш ээ” – гэж Модон хэлээд: - Ус нь илжирч өмхийрсөн боловч өмхий Амт чамд хор болохгүй нь мэдээж. Урагшаа!”

Өмхий Амт тэр муухай хоолойгоо хүртэл бохир руу орж, амь тэмцэн яаж ийгээд цаашилж байснаа живэх дөхөж, ямар нэг юмнаас шүүрэн тэлчигнэхэд нь Модон тэрнийг цаад талд гаргаж өгөв. Модон эргэж ирээд:

“Ямар ч гэсэн хүрчихлээ, шатаар мөлхөж, шүдээ тачигнуулж байгааг нь харахад жинхэнэ харх л байна. Цамхаг дотор сууж байгсад сууснаараа л сууж байна, нэг гар цухуйж тэрнийг татаад оруулчихлаа. Бодвол байгуулсан гавьяанд нь тохируулж угтаа биз дээ. Би явлаа, энэ муухай юмны бузрыг угаая. Хэн нэгэнд хэрэгтэй болбол би хойт хэрэм дээр байна шүү, энд цэвэр ус яагаад ч олдохгүй. Уух байтугай угаах ч ус олдохгүй, онт уухгүйгээр, угаахгүйгээр яасан ч болохгүй. Харин туулайхнууд минь, миний хаалгачаар түр ажилла. Энд одоо эрхэм хүндэт зочид ирнэ, ристаний эзэн захирагч өөрийн биеэр залрах гэж байна! Та хоёр ёс журмынхаа дагуу хүлээж ав. Тэр агуу ялалт байгуулаад ирж байгаа. Эзэн захирагчийн дайчид орхуудтай байлдаад ялсан. Тийм хүндэт зочныг яаж угтах ёстойг ойн жирийн онт яаж мэдэх вэ дээ. Та хоёр хүмүүсийн ёс горим, зан заншлыг биднээс илүү мэднэ шүү дээ. Ристанийн ногоон талд олон хаад ноёд зочилж байсан, гэтэл би тэдний хэлийг ч мэдэхгүй, нэрсийг нь ч мартаж орхисон байна. Тэдэнд хүнийг иддэг утаа хэрэг болох байх. Хайж олоод эзэн захирагчийг дайлаарай” гэсэн. Бидний хувьд чадах бүхнээ хийлээ. Гэвч би энэ өмхий Амт гэж хэн юм бэ гэдгийг мэдмээр байна. Нээрэн эзэн захирагчийн зөвлөх байсан юм уу?

- Байсан юм аа, - хэмээн Арагорн батлаад: - Бас Саруманы тагнуулчийн үүргийг хавсран гүйцэтгэж, тэрний Ристани дахь гол нүд чих болж байсан юм. Хувь заяа нь тэрнийг өршөөсөнгүй бололтой. Тэр бүх насаараа бишрэн дагаж, мөргөн зүтгэж байсан тэр агуу их хүчээ үнсэн товрог болохыг үзэж, хамаг хүсэл мөрөөдөл нь хог новш болохыг үзлээ. Тэр хангалттай шийтгэл амсч байгаа юм шиг санагдаж байна, гэхдээ үүнээс ч долоон дор юм тэрнийг хүлээж байгаа.

- Модон тэрэнд сайн санасандаа л Ортханк руу хөөх шахам оруулаагүй байх! – гэж Мерри хэлээд: - Тэр угаал үйлдэж, умдаа уухаар явахдаа тун ч зэвүүн инээж байсан. Бид хоёр дараа

нь бохир сувгаар урсч байгаа хог новшийг шалгаж, тааралдсан нүх сүв бүрийг нэгжсэн дээ. Эзэн хичээвэл заяа хичээнэ. Бид хоёр үерт автаагүй бүтэн гурван агуулах олсон. Даанч олонгуут Модонгийн онтууд хүрч ирээд бараг л бүгдийг нь хураагаад авчихсан. Тэд “Бидэнд хорин таван хүнд хангалттай хүрэлцэх хүнийг идэгч утаа хэрэгтэй байна” гэсэн. Тэгэхлээр та нарыг хүртэл оруулаад бүгдийг нэг бүрчлэн тооцоолсон байгаа биз. Гэхдээ та нар энд үлдсэндээ бүү гомд. Бид хоёр өөрсдийгөө юу гэж гомдоох вэ дээ. Харин уудаг юмнаас онтууд огт хороогоогүй. “Тэд чинь юу уух юм бэ?” – гэж би асуусан юм.

“Мэдээж Изений усыг ууна, онтуудад ч, хүмүүст ч бүрэн тохирно” гэж тэд хэлсэн. Ингэхэд онтууд булгийн уснаас өөрсдийнхөө умдаг гаргаж авсан байх, одоо Гэндальф буржгар сахалтай болоод ирнэ дээ. Товчоор хэлэхэд тэд ч яваад өгсөн, өлсч ядарсан бид хоёр амарч, идэж авна биз дээ. Бид хоёрт өр байхгүй шүү. Хүнийг иддэг утааг хичээл зүтгэл гарган хайж байгаад зүүдэнд ч ормооргүй сайхан утаа олсон. Пин Аянга Ниргэгчийн тамгатай энэ торхнуудыг чирч ирчихээд биеэ ихэд тоож ”өл авсны дараа өндийлгөхөд нүгэлгүй” гэсэн дээ. Ингээд л үлгэр дууслаа.

- Тийм ээ, одоо бүх зүйл тодорхой боллоо - гэж Гимли магтав.

- Нэг л зүйл тодорхойгүй байна, хоббитаны тамхины өвс өмнөд тойргоос яаж Изенгардад ирдэг байна? Би энийг л ойлгохгүй байна даа. Би урьд өмнө Изенгардад ирж байгаагүй гэж бодъё, гэвч Хоббитан, Мустангрим хоёрын хоорондох эзэнгүй хязгаарыг хөндлөн гулд олон удаа бэдэрсэн дээ. Тэндхийн зөрөг жим алга болсон, ер нь аюултай газар, юун бараа тээхтэй манатай. Тэгэхээр Саруманд нууцаар бараа хүргэдэг хоббитууд байсан шиг байна. Өмхий Амтууд зөвхөн Теодений алтан өргөөнд байдаггүй юм шиг байна даа. Тэр торхон дээр чинь он сар бичээгүй байна уу?

- Бичсэн байна аа, нэг мянга дөрвөн зуун арван долоон он гэж байна, тэгэхлээр уржнан жилийнх байна, тэр жил ч их сайхан ургацтай байсан даа – гэж Пин хэлэв.

- За за, тэр одоо муу муухай үйлээ аргагүйн эрхэнд орхино биз, бидэнд ч гэсэн тэрнээс өөр сонирхох юм байна. Гэлээ ч гэсэн би энэ тухай Гэндальфт хэлье. Дэмий юмыг ч гэсэн анхаарлын гадна орхиж болохгүй – гэж Арагорн хэлэв.

- Тэр тэнд юугаа хийгээд алга болчихов, мэдэх юмсан – гэж Мерри хэлээд: - Үд болчихлоо. Явж жаахан зугаалъя! Тэнэмэл чамд Изенгардыг үзэх завшаан тохиолдлоо. Гэхдээ хараад байх юм ч байхгүй дээ.

Бүлэг 10

Саруманы сайхан яриа

Тэд нурсан хонгилоор явж, чулуун нуранги дээр гарахад тэдний өмнө Ортханкийн нүсэр том овоолго туллаа. Түүний шагайвчин цонхнууд хоосорсон цайзыг урвагар бөгөөд заналтай харж байв. Үер бараг зогсч, ус цайзаас гадагшилжээ. Булинггартай хөөс бүхий бохир ус, элдэв хог новшоор дүүрсэн асар гүнзгий хонхрууд, бөөгнөрч овоорсон хайрга чулуу, тахийж муруйсан шонгууд үлджээ. Хэрмийн хойт талын цөмөрхийн тэндээс Ортханк руу морьтнуудын цуваа давхиж айсуй.

- Гэндальф, Теоден хоёр хамгаалагчидтайгаа ирж явна. Тэдний өмнөөс явцгаая- гэж Леголас хэлэв.

- Болгоомжтой яваарай! Хавтангууд тараад алга болсон, ямар нэг ёроолгүй нүх рүү уначихаж мэднэ шүү - гэж Мерри анхаарууллаа.

Тэд хуучин хаалганаас цамхагт хүрэх гол зам байсан хагархай, халтирамтгай хавтангууд дээгүүр урагшлав. Морьтнууд тэднийг хараад цамхгийн дэргэдэх асар том хясааны доор нуугдан хүлээв. Гэндальф өмнөөс нь хүрч ирлээ.

- Би Модонтой энээ тэрээ юм ярилцаж тохиролцоод ирлээ. Бусад маань энэ хооронд жаахан амарч авлаа. Одоо замд гарах цаг болов. Та нар ч гэсэн амарч, идэж ууж авсан гэж найдаж байна.

- Идэж уух нь байтугай, тавтай сайхан тамхилцгаасан. Бид одоо Саруманд ч нэг их уурлахгүй байгаа шүү - гэж Мерри сайрхав.

- Өө тийм үү? Харин би тэрэнд уур хүрсэн хэвээрээ, тэгээд ч одоо би тэрэнтэй тооцоо бодно. Уулзалт их аюултай, ашиггүй ч байж магадгүй, гэхдээ зайлшгүй. Хэн надтай хамт явахыг хүснэ, тэр хамт явж болно. Гэвч болгоомжтой л байж үзээрэй. Тоглоом биш шүү - гэж Гэндальф хэлэв.

- Би л лав явна, тэрнийг нэг сайн харж, өөртэй чинь харьцуулна. Та хоёр ихэр юм шиг адилхан гэж санагдаад байна – гэж Гимли хэлэв.

- Дэндүү их юм хүсч байгаа юм биш үү, эрхэм гном минь? Хэрэв Саруман хүсвэл чи тэрнийг надаас яагаад ч ялгахгүй. Тэрний урхинд орохгүй байхад ухаан чинь хүрэхгүй. Гэхдээ харж байж больё. Тэрний зөрүүд зан битгий хөдөлчихөөсэй. Уулзалтад дэндүү олуул очиж байна. Онтуудыг тэрний нүдэнд битгий үзэгдээрэй гэж захисан. Тэгэхгүй бол тэр азаа туршихаас буцахгүй.

- Ямар аюултай юм бэ? Тэр бидэн рүү харвах уу, галаар тургих юм уу эсвэл зайнаас илбэдэх үү? – гэж Пин асуув.

- Тийм ээ, тэр та нарын гэнэн хөнгөмсөгийг ашиглаж илбэдэх гэж оролдох байх. Ер нь тэрний толгойд юу орох, ямар зэвсэг хэрэглэхийг хэн мэдэх вэ? Тэр одоо буланд шахагдсан араатнаас ч аюултай. Саруман бол маш муухай санаатай, хүчирхэг шидтэн гэдгийг санацгаа! Тэрний үг хэлээс болгоомжлоорой!

Ортханкийн зургаан талт суурь болсон хар гантиг хясаа нойтноор гялалзана. Түүний хутганы ир мэт хурц ирмэгүүд дөнгөж сая хийсэн юм шиг. Нэлээд олон халцархай болон жижиг хэлтэрхийнүүд онтууд хэр их хилэгнэснийг харуулж байлаа. Зүүн талын өнцгийн багануудын хооронд нүсэр том хаалга байх бөгөөд түүний дээрх ширмэн хашлагатай тагт руу харсан төмөр хаалттай цонх байна. Балар эртний мастеруудын хар гантигаар урласан хорин долоон дугариг гишгүүр байна. Энэ бол нарийхан өндөр цонхнуудаараа гаднаас ирэгсдийг хялайн харж байгаа мэт олон нүдэт цамхаг руу орох цорын ганц хаалга ажээ.

Гэндальф, эзэн захирагч хоёр доод гишгүүрт тулж очоод мориноосоо буув.

- Би хаалган дээр очно, урьд нь энд ирж, дотор нь орж байсан болохоор Саруман намайг гэнэдүүлж чадахгүй – гэж Гэндальф хэлэв.

- Би ч гэсэн өгсөнө, хөгшин надад ямар ч ид шид аймшигтай биш. Эомер намайг өгсөхөд тусална – гэж Эзэн захирагч хэлэв.

- Тэг дээ, Арагорн надтай хамт явна. Бусад нь эндээ хүлээж бай. Эндээс харж, сонсоход хангалттай – гэж Гэндальф өгүүлэв.

- Үгүй шүү - хэмээн Гимли эсэргүүцэж: - Леголас бид хоёр ойрхноос харж сонсохыг хүсч байна. Та нарын араас дагая.

- За за, дагавал дага – гэж Гэндальф зөвшөөрөөд Теодентой зэрэгцэн шатаар өгслөө.

Морьгнууд шатны хоёр талаар даган өгсч, аймшиг төрүүлсэн цамхаг тэдний өөдөөс хялайн эзнийхээ төлөө санаа зовниж байлаа. Мерри, Пин хоёр доод гишгүүр дээр сууж үлдээд, тун ч их айж байлаа.

- Хаалганаас цааш бараг хагас бээр аймшгийн шавар, хог новш туучиж ирсэн шүү дээ – гэж Пин хэлээд: - Эндээс одоохон зугтаад харуулын байранд очиж нуугдах юмсан. Яах гэж бид хоёр эднийг дагаж ирэв дээ. Бид хоёрыг хэн ч дуудаагүй шүү дээ – гэж үглэв.

Гэндальф очроороо Ортханкийн хаалгыг цохиход бөглүүхэн цуурайлав.

Хөөе Саруман, гараад ир! – гэж тэр захирангуй хашгирав.

Хэн ч хариулсангүй хэсэг удав. Эцэст нь тагтны цаадах цонхны төмөр хаалт нээгдсэн боловч хэн ч үзэгдсэнгүй.

- Хэн бэ? Юу хэрэгтэй вэ? – гэж хэн нэгэн хашгирав.

Теоден овгосхийн цочлоо.

- Таньдаг дуу хоолой байх чинь. Анх энэ дуу хоолойг сонссон тэр өдрийг хараая – гэж тэр хэллээ.

- Чи зарц нь юм бол Саруманыг хурдан дууд өмхий Амт аа, түргэл – гэж Гэндальф тушаав.

Төмөр хаалт хаагдав. Тэд хүлээж байлаа. Гэнэт хүнгэнэсэн намуухан, сэтгэл татсан аятайхан өөр нэг дуу хоолой гарав. Энэ дуу хоолойг анх сонсоод, түүнд автсан хүн дараа нь хэлсэн үгийг нь эргэж санадаггүй, хэрэв санавал бишрэн бахаддаг ажээ. Хөгжим мэт уянгатай, мэргэн бөгөөд цэцэн шударга үг ярианд нь сэтгэл алдан баярлаж, аль болохоор хурдан тэр цэцэн ухаанд нь захирагдмаар болдог ажээ.

- За бас юу болчихоо вэ? – хэмээн тэр зэмлэнгүй асуув: - Заавал намайг босгож ирэх хэрэгтэй юм уу? Өдөр ч, шөнө ч амар заяа үзүүлэхгүй юм! – гэж тэр хэлэхэд дуу хоолойд сайхан сэтгэл, гэмгүй байхад нь доромжилсонд баахан гоморхсон өнгө илт байлаа. Бүгд дээш гайхан харвал хаанаас ч гараад ирснийг бүү мэд нэгэн өвгөн тэдний дээрээс тоомжиргүй харж зогсов. Тэрбээр ямар өнгөтэй нь үл мэдэгдэх халхгар урт нөмрөгтэй байх бөгөөд харж байгаа хүн нүд цавчих юм уу, өвгөн өчүүхэн хөдлөх төдийд өнгө нь солигдож байлаа. Гонзгой нүүртэй, өндөр духтай тэр эрхмийн бараавтар өнгөт нүд тэднийг баяртай, бага зэрэг ядрангүй мөртөө нэвт шувт ширтэж байв. Өтгөн цагаан үстэй, уруулаа тойрсон битүү сахалтай, чихнийхээ дээгүүр нэгэн туг урт хар үстэй аж.

- Тийм ч адилхан биш байна - гэж Гимли бувгнав.

- За тэгээд юундаа таг дуугүй зогсоод байгаа юм бэ? Ядаж хоёрыг нь би сайн таних юм байна. Гэндальфыг бол хэтэрхий сайн танина. Арай тусламж юм уу, зөвлөгөө авах гэж ирсэн юм биш биз дээ. Ристаниин эзэн захирагч Теоден чамайг танихгүй байхын аргагүй. Чиний цагаан сүлд чинь бардам гялалзаж, Эорлын удмын эзэн захирагч буянтай сайхан харагдаж байна. Оо, суу алдарт Тэнгэлийн нэр төртэй залгамжлагч минь! Чи яагаад ингэж их удав, ямар учраас найз, хөршийн хувьд аль эрт ирсэнгүй вэ? За, би ч гэсэн дээ! Өрнө газрын эздийн эзэн чамтай энэ бэрх цагт очиж уулзах хэрэгтэй байсан шүү дээ, хэрэгтэй байсан! Чамайг ухаан муутай, хорон зөвлөгөөнөөс сэрэмжлүүлэх хэрэгтэй байсан юм! Гэвч хараахан оройтоогүй юм биш үү? Чи тэнэг алдрын төлөө догшин баатар вангуудтайгаа нийлж надад хүнд цохилт өглөө, гэвч би өс хонзон өвөрлөхгүй ээ, юу ч боллоо гэсэн чамайг болон, хаант улсыг чинь одоо нэгэнт зайлшгүй болсон мөхлөөс аврахад бэлэн байна, яагаад гэвэл чамайг мэхэлж гаргасан энэ зам чинь ёроолгүй ангал руу хөтөлнө. Түүнээс ч илүүг хэлье. Ертөнц дээр ганцхан би л чамд тусалж чадна.

Теоден ямар нэг юм хэлэх гэсэн боловч үг нь аман дээр нь ирээд гацчих шиг санагдав. Тэр Саруманы нүүр рүү, уриалан дуудаж байгаа ширүүн харцат нүд рүү нь ширтэж байлаа, дараа нь Гэндальф руу харахад эргэлзээ түүнийг дийлэх шиг болов. Гэндальф доош харж, ямар нэг дохио хүлээж байгаа мэт тэвчээртэй, хөдөлгөөнгүй зогсоно. Морьт дайчид Саруманы үгийг сонсоод сайшаасан аястай дүнгэнэлдсэнээ илбэдүүлсэн юм шиг нам жим болов. Гэндальф тэдний эзэн захирагчид хэзээ ч ийм чин сэтгэлийн хүндэтгэлээр хандаж байгаагүй юм шиг тэдэнд санагджээ. Тэр Теодентой бүдүүлэг, дээрэнгүй харьцдаг санагдана. Тэдний зүрхийг зайлшгүй сүйрлийн хар совин шимшрүүлэх шиг. Гэндальф өөрийнхөө хүслийг биелүүлэхийн тулд Мустангримыг гай зовлонгийн ангал руу түлхэж байхад Саруман авралын замыг нээж

байна, түүний үгэнд найдварын гэрэл сүүмэлзэж байна биш үү?. Сэтгэл түгшүүлсэн нам гүм боллоо. Гэтэл гэнэт энэ нам гүмийг гном Гимли эвдэв.

- Тийм ээ, энэ бол шидтэн биш, ямар нэг зальтай луйварчин байна – гэж тэр тодхон хэлээд саран сүхнийхээ бариулаас атгаж: - Ортханы энэ луйварчингийн хувьд туслах гэдэг нь урвах, аврах гэдэг нь сүйрүүлэх гэсэн үг. Энэ тов тодорхой байна. Харин бид энэнээс тусламж гуйж, аврал эрж ирээгүй.

- Дуугаа аяд! – гэж Саруман зандрахад түүний дуу хоолой хоромхон зуурт дур булаам сайхан өнгөө алдаж, нүд нь хорсолтойёо гялалзав.

- Чамд ч гэсэн хэлэх юм байна аа, Глоины хүү Гимли, - Чиний орд өргөө эндээс алс хол байна, эндхийн элдэв холион бантан чамд хамаагүй. Чи өөрөө ч гэсэн ийм холион бантанд амьдралдаа ч хутгалдахгүй байсан. Би чамайг хуумгай шийдвэр гаргаж, цагаа олоогүй баатарлаг зориг гаргасныг чинь уучилж байна. Гэвч надад эхлээд Ристанийн эзэн захирагч, миний эртний хөрш бөгөөд андтай ярилцах боломж олго – гэж тэр түрүүчийнх шигээ аятайхан өнгөөр үргэлжлүүлэв:

- Чи юу гэмээр байна, эзэн захирагч Теоден? Ямар ч гэсэн бид найрамдъя, олон зуунд хуримтлуулсан эрдэм мэдлэг чамд хэрэг болох уу? Энэ хүнд цагт гар гараасаа барилцан тэмцэж, аль аль талын гомдлоо ор тас мартвал, манай найрамдалт хязгаар урьдахаасаа ч илүү цэцэглэн хөгжинө!

Гэвч Теоден эргэлзэж байгаа юм уу, уур хилэнгээ дарж ядан байгаа юм уу, хариу хэлсэнгүй. Эомер ярьж эхлэв:

- Намайг сонсооч, эзэнтэн минь! Яг ийм юм болно гэж бидэнд урьдчилан сануулсан шүү дээ. Бид хорт хатгуураасаа бал савируулж байгаа хөгшин худалчийн цонхон доор амаа ангайж зогсохын тулд л олон аюулт бэрх тулаанд ялсан юм гэж үү? Энэ чинь анч нохдын өмнөөс ичээн дотроосоо архирч байгаа хөгшин чоно л байна шүү дээ! Энэний туслах гэж юу байдаг юм бэ? Зүгээр л тарьсан гай гамшгийнхаа хариуцлагаас зугтаах гэж худлаа хуцаж байна. Чи Теодерыг гарман дээр, Гаймаг Хельмагийн цайзад оршуулчихаад энэ урвагч, цус сорогчтой ярих гэж үү?

- Могойн хатгуур гэнэ ээ? Харин чи өөрөө нуруу руу хатгах гэж санаархаж байгаа юм биш үү, могойн зулзага аа? - гэж Саруман хорслоо нууж чадалгүй хашгираад: - Гэвч ухаарч үз, Эомундын хүү Эомер минь! – гээд тэрний яриа дахин уяраах шидтэй уран өнгөндөө орж:

- Хүн бүр өөрт оногдсоныгоо хийдэг юм. Чи бол эрэлхэг баатар ван, алдар суу тань бадрах болтугай. Эзэн захирагчийн зарлигаар хайр найргүй цавч - энэ бол чиний гавьяат үйлс. Харин улс төрийг эзэн хаадад нь үлдээ. Улс төрд чи залуудна. Харин хаан ширээнд суух хувьтай бол эхлээд анд нөхрөө зөв сонгож сур. Үнэн, худал гоморхлоос болж Саруман, Ортханкийн агуу хүчтэй нөхөрлөхөөс татгалзах нь тэнэг хэрэг. Нэг тулалдаанд ялах бол ялалт хараахан биш, тэгээд ч та нар харийн аюултай тусламжийн хүчээр ялсан. Ойн мангасууд бол найдваргүй бөгөөд өөрийн онцлог зантай холбоотнууд. Цаг нь ирэхээр тэд та нар руу ч дайрч чадна. Яагаад гэвэл тэд хүмүүсийг үзэн яддаг юм.

Гэхдээ Ристаниин эзэнзахирагч дайнд эрэлхэг дайчдаа алдсанахаа төлөө намайг алуурчин гэж нэрлэж болох уу? Би дайтахыг хүсээгүй байтал над руу их цэрэг хөдөлгөж, намайг мэл гайхуулсан, тэгээд л тэднийгээ үхлийн аюулт талбар руу явуулсан. Хэрэв би цус сорогч юм бол Эорлын удмынхан хөлөөсөө толгойгоо хүртэл цусанд будагдсан байх. Учир нь түүний алдар цуутай түүхэнд олон дайн болж байсан. Гэхдээ дараа нь тэд найрамддаг байсан, яагаад гэвэл муу эвлэрэл ч гэсэн сайн хэрүүлээс дээр гэдэг юм. Тэгэхлээр эзэн захирагч Теоден өөрийн үгээ хэл дээ. Бид эвлэрч, найрамдлаа сэргээх үү, үгүй юу? Аль нь ч таны эрх мэдэл.

- Тийм ээ, бид эв найрамдлыг сэргээнэ - гэж Теоден бөглүүхэн дуугаар хэлэхэд ристаничууд баяртайгаар дуу алдацгаав. Теоден гараа өргөн тэднийг дуугүй болгоод:

- Тийм ээ, бид эв найрамдлыг сэргээнэ – хэмээн тод бөгөөд баттай хэлж:

- Чи үхэж далд ороод, чиний хар шидийн хар цайз нурж, чи биднээс урваж өөрийгөө худалдсан хар эзэн чинь ор мөргүй алга болсны дараа энх тайван сэргэнэ. Чи худалч, Саруман, худал үг оюун ухааныг өмхрүүлдэг. Чи над руу найрамдлын гар сунгаж байна уу? Энэ бол гар биш, энэ бол Мордороос сунгасан хар саврын хумс. Урт, бөх, хурц хумс! Чамаас болж дайн эхэлсэн: Чи арав дахин мэргэн байсан ч биднийг юуны ч нэрийн өмнөөс боол мэт бөхийнө гэж горьдох эрхгүй. Чи дайныг эхлээгүй байлаа ч гэсэн чиний орхууд Вестфольдод амьд бамбар шатааж, хүүхдүүдийг багалзуурдаж байсан. Тэд Горнбургийн хаалганы дэргэд Гаймагийн амьгүй биеийг хэсэглэж цавчсан. Тийм ээ, чи энэ цонхнуудын дэргэд дүүжлүүрээс унжганаж, өөрийнхөө найз хэрээнүүдийн амтат зууш болсны дараа бид Ортханктай найрамдана. Эорлын үр удам чамд ийм ял оноож байна. Би өвөг дээдсийнхээ нэрийг хугалж магадгүй л юм, гэхдээ чиний гар хөл болохгүй. Надаас бусдыг хуурч мэхлээд худалдахгүй юу, гэхдээ чиний дуу хоолой урьдын хүчээ нэгэнт алдсан байна шүү.

Ристаничууд амтат зүүднээсээ сэрсэн юм шиг Теоден руу алмайран харав. Саруманы сайхан ярианы дараа эзэн захирагчийнх нь дуу хоолой хөгшин хэрээний сөөнгө гуаглаа шиг сонсогдов. Харин Саруман галзууртлаа уурлав. Тэр тагтны хашлага дээгүүр бөхийж, эзэн захирагчийг газар дээр нь ниргэх гэж байгаа мэт зангахад яг л одоохон үсрээд хатгах гэж байгаа хорт могой шиг харагдлаа.

- Аах, дүүжлүүрт гэнэ ээ! – гэж тэр шүднийхээ завсраар сийгүүлэн хэлэхэд нөгөө сайхан дуу хоолой нь оргүй алга болсон байлаа:

- Ухаан муут зулбадас! Чиний Эорлын өргөө чинь согтуу алуурчингууд бөөлжсөндөө хутгалдаад хөндлөн гулдгүй хурхирч байдаг, бөөсөндөө баригдсан зулбасганууд нь золбин нохдын дунд мөлхөж байдаг өтөгний хашаа! Та нарыг л бүгдийг чинь дүүжлүүр хүлээж ядаж байгаа! Та нарын хоолойд дүүжлүүрийн гогцоо аль хэдийн углачихсан байна. Бат бөх, харгис хэрцгий, яардаггүй гогцоо. Одоо яая гэхэв, дуртай юм бол үхэж далд орцгоо! – гэж хашгираад тэр арайхийн өөрийгөө эзэмдэж, үг хэл нь өөр болов:

- Бүр тэвчээрийг минь барах нь ээ. Морь маллагч Теоден чи болоод сүүл хавчин зугаатаахаас өөр юм чаддаггүй хэдэн адуучин надад ямар хэрэг байна! Би чамд аль эрт санал тавьсан, ухаан муут чи хүлээж аваагүй. Дэмий л тэгж. Өнөөдөр ч гэсэн зайлшгүй үхэл рүүгээ явж байгаа золгүй амьтдыг аварья гэсэндээ дахиж санал тавилаа. Гэтэл чи хараал зүхлээр

хариулж сагсуурлаа. Одоо яая гэхэв, чинийхээр болог. Оромж руугаа тонил!

Гэндальф чи бас юу ч билээ! Би чамд бүхнээс илүү гашуудаж байна, чиний өмнөөс ичиж ч байна, уучлаарай. Чи над руу хэнтэй ирж байгаа нь энэ вэ? Чи их бардам, Гэндальф, тэгэхээс ч яахав. Чи гэгээн ухаантай, нэвтэрхий хурц хараатай. Чи одоо ч гэсэн миний үгийг сонсохгүй юу?

Гэндальф дээшээ харав:

- Чи надтай сүүлчийн удаа уулзахдаа ямар нэг юм хэлэхээ мартчихсан юм уу? Эсвэл хэлсэн ярьснаа буцааж авах гэж байна уу?

Саруман юу ярьснаа санаж, юу хэлэхээ бодож байгаа бололтой хариу хэлэлгүй хэсэг сатаарав:

- Буцааж авах ий? Юуг буцааж авах юм бэ? Чиний төлөө санаа зовж, чиний сайн сайхны төлөө санаа тавьсандаа би ухаантай зөвлөгөөгөөр туслахыг оролдсон, харин чи чихнийхээ хажуугаар өнгөрөөсөн. Чи жаахан зөрүүд, гуйгаагүй зөвлөгөө авах дургүй, өөрөө ч ухаанаар дутахгүй гэдгийг би мэднэ. Чи алдаж, намайг буруу ойлгосон байх, за ер нь гүйцэд сонсоогүй. Би бүх талаар зөв юм ярьсан, гэхдээ бага зэрэг уурласан юм шиг байна лээ, одоо тэгсэндээ их харамсч байна. Би зөвхөн чиний сайн сайхны төлөө л хичээсэн, хэдийгээр чи зэрлэг бүдүүлэг, хэрүүлч зодооч юмнууд дагуулж ирсэн ч гэсэн одоо ч хар буруу санасан юм алга. Чи бид хоёр муудалцаж болно гэж үү, Дундад газарт хамгийн гол зөвлөл, эртний дээд зөвлөлд хамтран оролцогч чи бид хоёрт тийм эрх бий гэж үү! Бид хоёр хэн хэндээ адилхан хэрэгтэй. Агуу их, сайн сайхан үйлс бүтээхийн тулд бие биендээ хэрэгтэй. Хий дэмий хэрүүлээ мартацгаая, бие биеэ ойлгож, хөндлөнгийн хүмүүсийг тэдний ухаан хүрэхгүй юманд оролцуулахаа больё. Чи бид хоёрын хамтарч гаргасан шийдвэр тэдний хувьд хууль болог! Нэг үгээр хэлэхэд би урьд өмнийн таагүй явдлуудыг мартаж, чамайг зүй ёсоор хүлээж авахад бэлэн байна. Харин чи... Өөрийнхөө бардам санаагаа дарж, нийтийн сайн сайхны төлөө хувийн гомдлоо мартаж чадна биз дээ? Дээшээ гараад ир, би хүлээж байна!

Түүний сүүлчийн энэ оролдлогод тийм гэхээргүй их татах хүч байсан учир сонссон хүмүүс сэтгэл алдарч, нам жим хүлээж байв. Шидэт дуу хоолой бүхнийг өөрчилжээ. Өгөөмөр буянт санваартан өөрийн хайртай эзэн захирагчийнхаа алдааг ил хэлж байгааг тэд сонссон. Тэд энд илүү байлаа. Сахилгагүй, хүмүүжил муутай хүүхдүүд тэдний хувьд нууцлаг боловч хувь заяаг нь шийдэж байгаа томчуудын яриаг сэм чагнасан юм шиг санагдаж байв. Энэ хоёр мэргэн, дархан эрх мэдэлтэн, шидтэн тэдэнтэй яаж дүйцэх билээ. Энэ хоёр мэдээж учраа ололцож л таарна. Одоо Гэндальф цамхагт орж, Ортханкийн өндөр өргөөнд хоёр буурал шидтэн жирийн ухаан хүрэхгүй их хэргийг хэлэлцэнэ. Тэд хаалттай хаалганы гадна зогсоод шинэ тушаал өгөх юм уу, шийтгэхийг хүлээнэ.

Теоден хүртэл “Энэ биднээс урвана, бид ч өнгөрлөө дөө” гэж өөрийн эрхгүй бодов.

Гэтэл тачигнатал инээхэд тэдний толгойд орсон бодол утаа мэт замхран арилав.

- Ээ, Саруман, Саруман! – хэмээн тэр инээдэн дундуураа хэлээд:

- Үгүй дээ, Саруман, чи боломжоо алдчихсан. Чи ордны алиа салбадай болж, хааны зөвлөхүүдийг элэглэн дууриаж байсан бол насны эцэст найдвартай талхтайгаа, хонхтой малгайтай үлдэх байсан юм. Мөн ярив аа! Бие биеэ ойлгоё гэв үү? Чи намайг ойлгохгүй байх гэж бодож байна, харин би чамайг ойлгохгүй байтугай нэвт харж байна. Чиний ажил хэрэг, баталгаа нотолгоо надад маш тодорхой байна. Түрүүчийн удаа чи Мордорын шоронгийн хуяг байсан, би Барад-Дураас оргосонд чиний буруу байхгүй. Үгүй дээ, хэрэв зочин чинь хашаа давж оргосон бол дараа нь түүнийг хаалгаар хуурч оруулна гэж байхгүй. Тиймээс хүлээх хэрэггүй, би орохгүй. Харин бууж ирэхээ бодсон чинь дээргүй юу? Чиний автагдашгүй Изенгард нуранги, нурам хоёр болчихсоныг харж байгаа биз дээ. Өөр цайзад нуугдана гэж дэмий найдаж байгаа юм биш биз? Биднийг дэмий тандаад байгаа юм биш биз? Эргэж хараад бод, Саруман! Нэг үгээр хэлэхэд бууж ирэхгүй юм уу?

Саруманы нүүрэн дээгүүр сүүдэр гүйж, царай нь үхсэн мэт цайв. Түүний багны цаанаас шаналгаат эргэлзээ харагдаж байлаа. Цайзад түгжээтэй үлдэх ичгэвтэр, ичээнээсээ гарах гэдэг аймшигтай. Тэр эргэлзээгээ давж чадахгүй золгч, яахыг нь бүгд амьсгаа даран хүлээж байв. Гэвч түүний дуу хоолой шинэ өнгөтэй боллоо. Бардам зан, хорсол занал нь дийлжээ.

- Буух тухай бодох гэж үү? – гэж тэр дооглонгуй асуугаад, - Дээрэмчдийн яриаг сайн сонсохын тулд тэдэнд зэвсэггүйгээр бууж өгөх гэж үү? Би эндээс ч та нарын яриаг сайн сонсч байна. Чи намайг хуурч чадахгүй, Гэндальф. Чамд захирагддаг нүднүүдээс далд хаана хилэнт шимнусууд нуугдаж байдгийг би мэдэхгүй гэж бодоо юу чи?

- Урвагчид хаа сайгүй урхи харагддаг юм – гэж Гэндальф ядрангуй хариулаад:

- Гэвч чи турсагныхаа төлөө дэмий айж байна. Чи намайг үнэхээр ойлгож байгаа бол эсэн мэнд, бүрэн бүтнээрээ үлдэнэ гэдгээ мэдэх ёстой. Харин ч би чамайг хамгаалж чадах байна. Шийдвэрлэх сонголтыг өөрт чинь үлдээе. Ортханкийг өөрийн зоргоор орхи. Чи чөлөөтэй.

- Гайхамшиг гэхээс өөр юу гэхэв! - хэмээн Саруман ярзайж:

- Саарал Гэндальф бас энэрэнгүй бөгөөд өршөөлт эзэн юм. Мэдээж, надгүйгээр чамд Ортханкт хамаагүй тохилог, уужим байх болно шүү дээ. Харин би яагаад эндээс явах ёстой юм бэ? Чинийхээр бол “чөлөөтэй” гэдэг чинь юу гэсэн үг вэ? Хөл гар нь хүлээстэй гэсэн үг үү?

- Ортханкаас яагаад явах хэрэгтэй нь чамд цонхоор харагдаж байгаа байх. Дээр нь өөрөө сайн бод. Чиний арми юу ч үгүй болтол бут цохигдсон, чи хөршүүдийнхээ дайсан болсон. Өнөөгийн эзнээ хуурсан буюу хуурах гэж оролдсон болохоор тэрний илд наашаа хандах юм бол үнс болгоно. Миний хувьд “чөлөөтэй” гэдэг бол юугаар ч хүлэгдэхгүй гэсэн үг. Хүлээсээр ч, андгай тангаргаар ч, баталгаагаар ч. Харсан зүг рүүгээ... хэрэв хэрэгтэй бол Мордор руу ч хамаагүй яв. Ганцхан болзол бий. Чи Ортханкийн түлхүүр, очир хоёроо надад өгнө. Хэрэв мөрөөрөө байх юм бол дараа буцааж өгнө, барьцаа гээд л бодчих.

Саруманы царай сааралтаж, муруйгаад, нүд нь хилэнгийн галаар дүрэлзэж, зэрлэгээр хөхрөв:

- Дараа! – хэмээн хашгирч:

- Мэдээж дараа! Чи Барад-Дурын түлхүүрийг олж авсны дараа юу? Долоон хааны титэм, таван очрыг тавууланг нь эзэмшиж, тэнгэртэй эн чацуу болсныхоо дараа юу? Арай ч үгүй байлгүй! Чамд бага юм хэрэгтэй, миний даруухан тусламжгүйгээр болно. Харин би явж өөр юм хийлээ. Харин золгүй тэнэг минь одоохондоо эсэн мэнд байгаа дээрээ арилж үз. Гэнэт миний хэрэг болбол эрүүл болчихоод ирээрэй! Тэхдээ энэ муусайн алуурчдын бүлэг, хөөрхий сүүлээ битгий дагуулж ирээрэй! Баяртай! – гээд тэр эргэж, тагтан дээрээс алга болов.

- Гараад ир, Саруман! - гэж Гэндалф тушаав. Гайхалтай нь Саруман хэн нэгний үл үзэгдэх гар суга татаад гаргаж ирэх мэт тагтан дээр дахин гарч ирэв. Тэр ширмэн хашлага дээр удаанаар тонгойж амьсгаагаа арайхийн дарж байлаа. Үрчлээт нүүрэнд нь дусал ч цус байгаа шинж тэмдэггүй, том хар очир барьсан гар нь ясандаа хүртэл үжирсэн мэт харагдана.

- Би чамд явах зөвшөөрөл өгөөгүй, чамтай яриагаа дуусгаагүй байна. Чиний ухаан мууджээ, Саруман, чи надад харамсалтай байна. Хэрэв чи хар муу үйлд авгаж, ухаангүй загнахаа болих юм бол хичнээн сайн үйл бүтээхсэн. Гэвч чи өөрийгөө хөөж оруулсан хавхаа мэрэх зам сонголоо. Одоо яая гэхэв, хавхтайгаа үлд! Гэвч гадагшаа гарах замгүй гэдгийг санаарай. Дорноос чам руу бахим хар гар сарвайхгүй л бол. Саруман! – гэж Гэндалф хашгирахад түүний дуу аянга мэт чанга тасхийв:

- Мэдэж ав, би чиний дайсанд худалдаж байсан урьдын Саарал Гэндалф биш болсон, би Цагаан Гэндалф, үхэл надад дархан эрх олгож чөлөөлсөн юм! Харин чи энэ мөчөөс эхлэн өнгөгүй болсон, би чамайг Гэгээн Мэргэдийн Зөвлөлөөс хөөлөө! – гээд гараа өргөж тодхон бөгөөд чанга дуугаар:

- Саруман, чиний очрыг хураалаа!

Тасхийх чимээ гарч, Саруманы гарт байгаа очир хугарч, толгой нь Гэндалфын хөл дор унав.

- Одоо яв! – гэж Гэндалф тушаахад Саруман нэгэнтээ хашгираад сөхрөн унаж, мөлхөн одов. Тэгтэл дээрээс ямар нэгэн хүнд, гялалзсан юм унаж, Саруманыг шүргэх шахан өнхөрч, Гэндалфын хажуугаар шатан дээр унав. Шатны хашлага бут үсэрч, шатнаас гал дөл оволзлоо. Унасан бөмбөлөг гишгүүрээр доош өнхөрч, ус тогтсон хонхорт ороход нь Пин барьж авлаа. Хар өнгөтэй, дотроосоо хүрэнгэсэн болор бөмбөлөг байв.

- Өөдгүй муу новш! - гэж Эомер хэлэхэд Гэндалф мөрөө хавчиж:

- Үгүй ээ, энэ Саруманы ажил биш. Өөр нэг өндөр цонхоор шидсэн. Өмхий Амт бидэнтэй салах ёс гүйцэтгэлээ, гэхдээ амжилтгүй.

- Яагаад гэвэл тэр хэнийг онилохоо сайн мэдэхгүй байсан, чамайг уу, Саруманыг уу - гэж Арагорн хэлэв.

- Магадгүй – гэж Гэндалф зөвшөөрөөд: - Таарсан ч хоёр бол доо! Энэ хоёр бие биеэ иднэ. Хамгийн аймшигтай үг. Товчхондоо үйлийн үрээ эдэлнэ. Хэрэв өмхий Амт Ортханкаас амьд гарвал аз нь тэр... – гэснээ гэнэт эргэн харж, маш хүнд ачаа үүрсэн аятай шатаар удаан өгсч яваа Пинийг хараад:

- Хүүе, жижиг ээ, наад бөмбөлгөө орхи! Эхлээд надаас асуух чинь яасан юм бэ! – гэж хашгирав. Тэгээд хоббитын өмнөөс гүйн очиж, нөмрөгнийхөө хормойгоор бөмбөлгийг ороож аваад:

- Цаашхийг нь би мэдье – гэв.

- Тийм дээ, Саруман ийм юмнууд ийш тийш нь шидэхгүй. Тэрэнд энэнээс өөр шидэх юм зөндөө байгаа, уулзалт дууссан бол ядаж эндээс холдье - гэж Гимли хэлэв.

- Уулзалт дууссан, холдье - гэж Гэндальф зөвшөөрлөө.

Шатны дэргэд үлдсэн ристаничууд эзэн захирагчдаа баяртай бөгөөд чангаар баяр хүргээд, Гэндальфт мэхийн ёсолцгоов. Саруманы илбэ ор мөргүй алга болж, тэд бүгдээрээ түүнийг хорсолдоо шатаж байгаа хөөрхий шившигт амьтан болохыг нь таньжээ.

- За ингээд боллоо – хэмээн Гэндальф санаа алдаад: - Уулзалт яаж дууссаныг Модонд дуулгах хэрэгтэй дээ.

- Тэр мэдэхгүй гэж үү? Уулзалт өөрөөр дуусч болох байсан юм уу? – гэж Мерри гайхав.

- Бараг л үгүй байсан даа, гэхдээ л хутганы ирэн дээр байсан. Гэхдээ л нэг талаар энэрэнгүй сэтгэлийн үүднээс, нөгөө талаар Саруманд дуу хоолойн шид чинь дууссан гэдгийг үзүүлье гэж бодсон юм. Харгис дарангуйлагч зөвлөх болж жүжиглээд байх хэрэггүй. Нэгэнт нууц нь илэрсэн юм чинь цаашид нуух боломжгүй шүү дээ. Гэтэл энэ этгээд юу ч болоогүй юм шиг биднийг боловсруулж эхэлдэг байна шүү. Бид хоёрын сонгол өөр өөр гэдгийг тэр тооцоолсонгүй. Гэлээ ч гэсэн түүнд Мордороос татгалзах сүүлчийн боломжийг олгох хэрэгтэй байсан юм, далимд нь өөрийнхөө хар санаанаас салах боломж олгоё гэж бодсон юм. Ичгүүрт нүглээ цагаатгаж, бидэнд их тус хүргэж чадах байсан. Тэр бидний ажлыг хэнээс ч илүү мэднэ, хүсэх л юм бол одоо бүх юм өөрөөр эргэх байсан юм. Гэвч тэр өөрийнхөө ямар ч хүчгүй өшөө хорслоо, найдваргүй болсон Ортханкаа сонголоо. Туслах хүсэлгүй, жанжлах хүсэлтэй гэнэ. Мордорын хар сүүдрийн өмнө байгаа мөртөө дээд эрх барихыг хүсч байдаг. Ёстой золгүй тэнэг! Хэрэв дорноос түүн рүү хүрч ирвэл дуусах нь тэр. Бид Ортханкийг нураахгүй, нураая гэсэн ч чадахгүй, харин Саурон бол чадна ч, нураана ч.

- Хэрэв ялалт Сауронд олдохгүй бол яах вэ? Чи тэгвэл Саруманыг яах вэ? – гэж Мерри асуув.

- Би юу? Саруманыг уу? Яах ч үгүй, ямар ч эрх дарх надад харш, харин тэрэнд юу тохиолдохыг би мэдэхгүй. Харамсалтай л байна. Хичнээн их баялаг, хичнээн их хүч чадал дэмий хоосон өнгөрч байна вэ. Бидэнд ч их аз тохиолоо шүү! Хорон санаа биеэ отно гэдгийг урьдаас тааж мэдэхгүй юм даа. Бид Ортханк руу орсон ч гэсэн тэндхийн их эд баялаг дотроос өмхий Амтын шидсэн шиг үнэтэй эрдэнэ олохгүй л байсан даа.

Цамхгийн нээлттэй өндөр цонхоор улайран хашгирах дуу сонсдоод тасалдав.

- Саруман миний саналыг зөвшөөрч байх шиг байна. Одоо хурдхан холдье! – гэж Гэндальф хэлэв.

Тэд түргэлж, нурсан хаалганд хүрээд нуман хаалгаар дөнгөж гартал овоорсон чулууны цаана нуугдаад хүлээж байсан онтууд гарч ирэв. Модон түрүүлэн явж байх бөгөөд Арагорн, Гимли, Леголас нар ойн аваргуудыг гайхан ширтлээ.

- Ингэхэд миний гурван дагуул энэ байна. Би чамд ярьж байсан даа, Модон. Гэвч та нар хараахан уулзаагүй байгаа - гээд Гэндальф тэр гурвыг дэс дараалан танилцуулав. Өвгөн онт тэднийг анхааралтай харж, тус бүртэй нь хэдэн үг солилоо. Сүүлчийнх нь Леголас болов.

- Тэгэхлээр эрхэм эльф минь, чи одоо Бөглүүд ой гэж нэрлээд байгаа газраас ирсэн байх нь ээ? Юу ч гэж нэрлэлээ гэсэн тэндхийн ой ёстой жинхэнэ ой доо!

- Тийм ээ, манай ой одоо ч гэсэн дажгүй шүү - гэж Леголас даруухан хэлээд:

- Хичнээн их модтой ч гэсэн бага л санагдаад байна! Ертөнц дээр миний хамгийн их хүсч байгаа зүйл бол Фангорны ойгоор тэнэх. Захаас нь цааш явж үзээгүй, гэтэл сэтгэлийг минь ёстой соронздож байна!

Модонгийн цэнхэр нүд баяртай гялалзав.

- Чиний хүслийг биелэхэд уулс ч гэсэн нэг их хөгшрөөгүй байх биз дээ – гэж тэр хэлэв.

- Биелэх л хэрэгтэй байна, би найзтайгаа энэ дайнаас амьд мэнд гарвал Фангорноор заавал аялна гэж тохиролцсон юм, мэдээж чиний зөвшөөрлөөр шүү дээ.

- Бид эльфүүдэд ямагт баярлаж байдаг.

- Найз маань эльф биш л дээ, худлаа хэлээд яахав. Глоины хүү Гимли, энэ зогсч байна.

Гимли мэхийн ёслохдоо дэндүү бөхийсөн тул саран сүх нь бүснээсээ мултарч чулуун дээр ханхийн ойчив.

- Кгм, хм! Мөн зочноо олов оо! – гэж Модон хэлээд Гимли рүү дурамжхан харж: - Гном, дээр нь бас сүхтэй! Ёстой мэдэхгүй юм даа! Кгм! Эльфүүдийг бид ямагт баяртай хүлээж авдаг гэж би хэлсэн, харин энэ ч арай дэндэнэ ээ, мөн найз сонгов оо...

- Анд найзыг сонгож авдаггүй - хэмээн Леголас зөрүүдэлж: - Нэг л юм хэлье: Гимли амьд байгаа цагт би Фангорн руу өрөөсөн хөлөө ч зүглүүлэхгүй. Энэ сүхээрээ мод цавчдаггүй юм, хязгааргүй их ойн эзэн минь! Орхуудын л толгойг цавчдаг юм. Сүүлийн нэг тулалдаанд дөч гаруйг өнхрүүлсэн.

- Кхум! Юун сайн юм бэ! Энийг ч харин сонсоход сайхан байна шүү. За за, заяа нь мэдэг. Очвол очно л биз. Бид юундаа яарах вэ. Харин одоо салах цаг боллоо. Орой ч болж байна, та нар шөнө дөл болтол явна гэж Гэндальф хэлсэн. Ристаниин эзэн захирагч алтан өргөө рүүгээ яарч байна.

- Тийм ээ, даруй хөдлөх хэрэгтэй байна. Харин чиний хаалгачдыг би авч явна. Чи тэдэнгүйгээр ажлаа сайхан амжуулна шүү дээ – гэж Гэндальф хэлэв.

- Амжуулах нь ч амжуулна л даа, гэвч явуулахад харамсалтай байна. Би эдэнтэй их хурдан, шууд хэлэхэд хам хум нөхөрлөсөн. Би өөрөө ч гайхаад байгаа юм, хөгширч зөнөөд хүүхэд болж байгаа юм байлгүй дээ. Гэвч бодоод үзвэл гайхаад байх юм алга. Би нар, саран доор хичнээн зуун жил шинэ юм юу ч үзсэнгүй, гэтэл... Хэнийг ч гэсэн мартлаа гэхэд энэ хоёр миний ой дуртгалд үлдэнэ ээ. Би хоёуланг нь нэрсийн жагсаалтад оруулсан, энэ дууг цээжилж ав гэж онтуудад тушаана:

Ойн сүргийг хариулагч, газрын шүүсийг уугч

Онтууд- аварга биетүүдийнд зочилж

Амтганыг идэгч, хүний туулайнууд

Алиа хошин, эрэлхэг хоббит хөвгүүд ирлээ.

Модон дээр навчис ургаж байгаа цагт ингэж дуулах болно. Баяртай! Хэрэв танай сайхан Хоббитанд ямар нэг мэдээ хүрвэл надад мэдээлээрэй! Би юун тухай ярьж байгааг та хоёр мэдэж байгаа биз дээ? Онтжингуудыг л хэлж байна. Гэнэт ямар нэг юм үзэх юм уу, сонсч магадгүй шүү дээ. Өөрсдөө ч гэсэн манайд ирээрэй!

- Бид ирнэ ээ! - гэж Мерри, Пин хоёр нэгэн дуугаар хэлээд зэрэг нүүрээ бурууллаа. Модон тэр хоёрыг дуугүй харснаа толгой сэгсрэв. Тэгээд Гэндальфт хандаж:

- Саруман гарч ирэхээсээ айсан юм биз дээ? Би үүнийг мэдэж байсан юм аа. Тэрний дотор тал нь адгийн ярихай шиг өмхөрчихсөн юм. Үнэнийг хэлэхэд тэр намайг ялаад бүх модыг минь яйруулчихсан бол би аль нэг нүх олж орчихоод хамраа ч цухуйлгахгүй байсан.

- Дэмий харьцуулалт байна! – гээд Гэндальф: - Чи өөрийнхөө модоор дэлхийг дүүргэхийн тулд бусад бүх амьдралыг сөнөөх гээгүй. Харин Саруман тэгсэн, тэр өөрийнхөө хар хорын санааг гүйцэлдүүлж, шинэ шинэ хар шидээр дэлхийг дүүргэх гэсэн. Ортханкийн түлхүүрийг тэрнээс авалтгүй, тэгэхээр тэрнийг тэндээс нь гаргаж хэрхэвч болохгүй.

- Санаа бүү зов! Онтууд тэрнээс өдөр шөнөгүй нүд салгахгүй, тэр миний зөвшөөрөлгүйгээр нэг ч алхахгүй – гэж Модон амлав.

- Тэгвэл сайн байна! Би зөвхөн та нарт л найдаж байсан юм. Ядаж ганц асуудал ч болов хорогдог. Тэгэхгүй бол би тэрэнтэй орооцолдохтой манатай байна. Гэвч та нар сэрэмжтэй байх хэрэгтэй. Зөвхөн цамхгийн эргэн тойронд харуул тавиад нэмэргүй, Ортханкаас газар доогуур явж гарах гүний хонгил зам байж таарна, Саруман түүгээрээ гарна гэж тооцсон. Хэрэв тэрэндээ тулбал та нар дахиад нэг сайхан живүүлээд орхи, тэгэхдээ ямар ч зам олдохооргүй, бүр нуур болгочих. Саруман цамхагтаа суугаад цонхоор харж байна биз.

- Онтуудад найдчих! Бид сөөм газар ч үлдээлгүй тэмтрээд бүх чулууг нэгийг ч үлдээлгүй эргүүлж харна! Эргэн тойронд нь зэрлэгшсэн хөгшин моднууд суулгана. Тэднийг харуулын ой гэж нэрлэнэ. Нэг ч хэрмийг алдалгүй ажиглах болно. Санаа бүү зов! Тэрний бидэнд учруулсан гай зовлонгийн хугацаа долоо дахин өнгөрсөн ч бид тэрнийг хараанаасаа

салгахгүй!

баруунаа ташиж байх үеэр Гэндальф дагалдагсдын хамт Изенгардыг орхин одов. Мерри Гэндальфтай, Пин Арагорнтой сундалджээ. Мэдээ хүргэгч хоёр сум мэт урагш довтолсоор хөндийг төдөлгүй орхиход нөгөөдүүл нь араас нь тайван хатируулж явав.

Онтууд хаалганы дэргэд ажил хэрэгчээр харуулд гарчээ. Тэд урт гараа энгэртээ аван хөшөө мэт хөдөлгөөнгүй зогсоно.

Мушгиралдсан замын эргэлт бүхэн дээр Мерри, Пин хоёр тушаал авсан мэт тэднийг эргэн харж байлаа.

Тэнгэрт нар гэрэлтсээр байсан ч Изенгардын саарал балгас үдшийн бүрийд автжээ.

Цайз хараанаас алдарсангүй, модны хожуул мэт харагдана. Нарны гэрэл булхсан уулын хөндийд Фангорын титмийн ойролцоо анх уулзсанаа хоббитууд эргэн санав.

Тэд Цагаан Далийн баганад ойртож очиход багана урдынхаараа байсан ч дээд хэсэг нь эмтэрч, ан цав гарчээ. Замын дунд цусанд бялдагдсан хар хумстай үхмэл цагаан урт долоовор хуруу газарт хэвтэж байв. Энэ бүхнийг хараад Гэндальф - Энэ онтууд чинь ямар гээчийн хүч чадалтай амьтад вэ гэж шогшров.

Тэд хажуугаар нь өнгөрлөө. Бүрэнхий өтгөрч эхлэв.

- Одоо бид хэр хол явах вэ, Гэндальф? - гэж Мерри хэсэг явсны дараа асуугаад: - Ард чинь өчүүхэн сүүл санжганаж яваа нь чамд хамаагүй л байх, гэвч сүүл урьд нь их ядарсан, тэр амрах юмсан гэж тэсч ядаад л байна.

- А-а, сонсчихож, тэр ч байтугай бүр гомдчихож! - гэж Гэндальф инээгээд: - тэгснээс Саруманд эелдэг занд чинь баярлалаа гэж хэлсэн нь дээр дээ! Тэр та нар руу тун ч айхтар харж байна лээ. Мэдмээр байвал бүр бахархаж ч болно – Тэр одоо зөвхөн Пин та хоёрын тухай л бодож байгаа. Хэн юм бэ, хаанаас гараад ирсэн юм бэ, энэ хоёр юу мэдэж байгаа бол, нөгөө олзлогдсон хоёр юм болов уу, мөн бол яаж аврагдсан юм бол гээд л. Манай агуу их мэргэн ийм л жижиг оньсого таах гэж үйлээ үзэж байгаа даа. Тэгэхлээр, эрхэм анд Мериадок, түүний зүхлээр биеэ тоож болно шүү.

- Буян үйлдэж байна уу! Гэвч миний хувьд чиний ард санжганаж явах илүү бахархалтай байна, ядаж саяны асуултаа давтаж болно. Одоо бид хэр хол явах вэ?

- Мөн ч уйгагүй хоббит юм даа! – хэмээн Гэндальф тачигнатал инээж:

- Шидтэн болгонд нэг ийм хоббит наачих юм бол шидтэнүүд хэлсэн үгээ эргэж харж байхгүй юу. Хариу хэлээгүйд уучлаарай, хариулт нь энгийнээс энгийн. Өнөөдөр бид яаралгүй хэдэн бээр яваад хөндийгөөс гарна. Маргааш шувт давхина. Бид Изенгардаас талын замаар Эдорас орох гэснээ больсон юм. Хельмагийн цайз руу элч илгээж, эзэн захирагч маргааш ирнэ, дайчдыг цуглуул гэсэн мэдээ хүргүүлсэн. Дунхерг рүү уулын жимээр явна.

- Нэг бол чамаар нэг ч үг хэлүүлж чадахгүй юм, нэг бол зөндөө олон үг сонсох юм. Би зөвхөн хоноглох газар хүртэл хол уу? гэж л асуусан. Тэр

Хельмагийн цайз, Эдорас мэдорасыг би мэдэж яах юм бэ? Эвсэл би харийн хүн юм уу!

- Ямар нэг юм мэдэж авъя гэж хүсч байгаа бол бүгдийг мэдэж ав! Миний бодолд битгий саад хийгээд бай.

- За за, галын дэргэд суухаараа Тэнэмэлийг бараадна аа, тэр ийм ууртай биш. Ганцхан л юм хэлчих, яах гэж бид ингэж нуугдаад байгаа юм бэ, бид чинь ялсан шүү дээ.

- Ялсан учраас л нуугдаж яваа юм. Бид толгойгоороо дэнчин тавьж ялсан. Изенгард Мордортой шууд холбоотой, тэд яаж мэдээ өгч авалцдагийг бодоод бодоод олохгүй юм, гэвч өгч авалцсан л байгаа юм даа! Одоо Барад-Дурын нүд Илбийн хонхорыг шөвөгдөж, Ристани даяар эргэлдэж байгаа. Тэр хичнээн багыг үзнэ, төчнөөн сайн.

Зам хөндийгөөр мушгирч, Изений чимээ нэг холдож, нэг ойртож байлаа. Уулнаас шөнийн харанхуй мөлхөж ирэв. Манан сарниж, хүйтэн салхи үлээлээ. Дорно зүгт тэргэл сар цайвартан гялалзав. Баруун талын гинжин уулс нүцгэн толгод болж хувирлаа. Тэдний өмнө уудам саарал хөндий цэлсхийв.

Тэгээд тэд зүүн тийш жолоо эргүүлж, зөөвлөн өвс өвч ургасан талаар нэг хоёр бээр яваад Манант нурууны захын уулын өтгөн бугаар хучигдсан Дол-Браны ногоон бэлийн цаадах дэнж дээр гарав. Шөнө дундаас ойролцоогоор нэг цагийн өмнө мориноосоо бууж, мод мэт том, аль хэдийн гөлөглөж эхэлсэн хөгшин бутны ёроолд галаа асаав.

Хоёр нь харуулд гарч, бусад нь нөмрөг, хөнжлөөрөө хучаад нам унтав. Хоббитууд зузаан овоорсон навчис дээр тухаллаа. Меррийн зовхи хүндэрч байсан боловч Пиний нойр яагаад ч юм хүрсэнгүй. Тэр навчсан дэвсгэрээ шаржигнуулан эргэж хөрвөөсөөр байв.

- Юу болоо вэ? Шоргоолжны үүрэн дээр хэвтчихээ юу? – гэж Мерри асуулаа.

- Үгүй дээ, зүгээр л тохигүй байна. Хөнжил нөмөрч унтаагүй хэд хоносноо л бодож байна.

Мерри амттайхан эвшээгээд:

- Хуруугаараа тоол! Бодоод байх юу байдаг юм бэ, Лоризэнээс хойш хүн шиг унтаагүй дэг гэв.

- Хм! Жинхэнэ ор дэр, унтлагын өрөөнд

- Тэгвэл Уудам хөндийгөөс хойш. Харин өнөөдөр бол би өргөсөн дээр ч хамаагүй унтмаар байна.

- Чи ч яахав, Мерри, Гэндальфтай явсан юм чинь.

- Тэгээд юу гэж?

- Чи түүнээс ямар нэг юм мэдэж авч чадав уу? Эсвэл чадсангүй юу?

- Чадсаан, урьдынхыг бодвол нэлээн юм мэдэж авсан. Гэхдээ чи хажууд явж байсан шүү дээ, бид хоёр чанга ярьж байсан, сонсоо биз дээ. За за, чи их юм дуулмаар байгаа бол маргааш түүнтэй яв, тэр зөвшөөрөх юм бол.

- Тийм үү? Болох уу? Сайхан аа! Тэр нөгөө л нууцалдаг хэвээрээ байна уу? Огт өөрчлөгдөөгүй байна уу!

- Маш их өөрчлөгдсөн! – гэж Мерри зүүрмэглэснээ сэрээд: - Тайлбарлахад хэцүү байна. Миний бодлоор бол тэр илүү сайхан сэтгэлтэй, хатуу ширүүн, хөгжилтэй болсон шиг байна. Нэг үгээр хэлэхэд тэр өөр болсон байна, гэхдээ огт өөр биш л дээ, одоогоор учир нь олдохгүй л байна. Саруман яаж дууссаныг сана л даа! Саруман урьд нь тэдний зөвлөлд Гэндальфаас том байсан, ямар ч зөвлөл юм бүү мэд. Тэр Цагаан Саруман байсан. Гэтэл одоо Цагаан Гэндальф Саруманыг гараад ир гэсэн, тэр гараад ирсэн, очир нь хуга үсэрсэн, яв гэж тушаахад нь дөрвөн хөллөөд л алга болоод өгсөн!

- Мэдэхгүй юм даа, гэхдээ л түүний нууцлаг зан урьдахаасаа нэмэгдсэн байна - гэж Пин зөрөөд: - жишээ нь тэр... нөгөө болор бөмбөлөг. Тэрнийг гартаа оруулсандаа их сэтгэл хангалуун байх шиг байсан. Юун бөмбөлөг болохыг мэдэж байгаа, эсвэл таамаглаж байгаа. Бидэнд нэг ч үг хэлээгүй. Тэр бөмбөлгийг би барьж авсан шүү дээ, би байгаагүй бол тэр цөөрөмд живэх байсан. “Хүүе жижиг ээ, наад бөмбөлгөө орхи” тэгээд л гүйцээ. Нээрэн юун бөмбөлөг юм бол? Хүнд гэж жигтэйхэн... - Пин өөртэйгээ ярьж байгаа юм шиг бүр аяархан ярьж байв.

- Аа! Тэгээд л чи эргэж хөрвөөгөөд байгаа юм байна л даа! Сонс миний найз Пин, чи Гаральдын хэлсэн үгийг сана даа, тэр үгийг Сэм дахин давтан хэлэх дуртай шүү дээ: “Мэргэдийн хэрэгт хамраа бүү дүр, толгойгоо алдана!”

- Энэ хэдэн сард бид мэргэдийн хэрэгт аргагүйн эрхэнд чихэндээ хүртэл шигдлээ шүү дээ. Толгойгоороо дэнчин тавиад л хийгээд байгаа. Тэр бөмбөлөг рүү харахад тийм ч их том шагнал баймааргүй л юм!

- Чи унтаад өгөөсэй, нээрэн шүү! Бүгдийг чи цаг нь болохоор мэднэ. Сониуч зангийн хувьд нэг ч Молтогчин Брендизайкаас давж байгаагүй юм, чи ч гэсэн харанхуй шөнө удам судрынхаа нэр төрийн төлөө зогсохоор шийдсэн юм биз дээ? Цагаа олсонгүй дээ!

- Чи мөн ярив аа! Би зүгээр л тэр бөмбөлгийг хармаар байна гэж хэлсэн. Гэндальф өвсөн дээр хэвтэж байгаа нохой шиг тэрэн дээр хэвтэж байхад яаж харах вэ дээ. Дээрээс нь чи бас юу гэнэ вэ? Болохгүй болохгүй, унт унт! Сайхан үг хэлсэнд баярлалаа!

- За за, чи намайг уучлаарай, Пин, гэвч өглөө болтол яаж ийгээд тэсч үз. Унтаж амаръя, өглөөний цайгаа ууя, тэгээд шалж өгье – хоёулаа дайрахад шидтэнгийн дотрыг уудална гэж мэд! Харин одоо үүнээс илүү тэсч чадахгүй нь, чихэндээ хүртэл эвшээж байна. Сайхан нойрсоорой!

Пин хариу дуугарсангүй. Тэр хөдөлгөөнгүй хэвтэж байсан ч огт нойр хүрч өгсөнгүй, сайхан унтаж байгаа Меррид уур хүрэх шиг. Анир чимээгүй болох тусам түүний нүдний өмнө хар бөмбөлөг залхуутай эргэлдээд байлаа. Тэр дахиад бөмбөлөг рүү гараа сунгаж, хоромхон зуурт харж амжсан хүрэн улаан дотор тал нь харагдах шиг болно. Пин дахиад л эргэж хөрвөн өөр юмны тухай бодохыг хичээв.

Гэвч яагаад ч нэмэр алга. Эцэст нь тэр босч суугаад эргэн тойрноо харав. Тэр салганан чичирч, цуваа өмсөв. Тод цагаан сар дэнжийг хүйтэн гэрлээрээ гийгүүлж, бутнууд нүүрсэн хар сүүдэр унагана. Эргэн тойронд бүгд унтаж байна. Харуулууд үзэгдсэнгүй. Уул өөд явсан юм уу, хаа нэгтээ бутан дотор сууж байгаа бололтой. Ямар нэг ойлгомжгүй, давагдашгүй хүчинд авгсан Пин тайван унтаж буй Гэндальф руу чимээгүй гэтэж очоод нүүр рүү нь харав. Шидтэн унтаж байгаа мөртөө зовхи нь хагас нээлттэй байв. Түүний урт сормуусны доороос хүүхэн хараа нь гялалзаж харагдана. Пин яаран ухарсан боловч Гэндальф хөдөлсөнгүй, хоббит ямар нэг юманд түлхүүлж байгаа юм шиг түүний араар тойров. Шидтэн хөнжлийнхөө дээгүүр нөмрөгөөрөө хучсан байх бөгөөд баруун гар доогуур нь бараан бөсөнд боосон бөөрөнхий юм байлаа. Гэндальфын гар дөнгөж сая боодолтой юман дээрээс гулгаж, газар буусан бололтой байлаа.

Пин дөнгөн данган амьсгалж, ойртон ойртсоор өвдөг дээрээ сууж, хоёр гараа сунган боодолтой юмыг авч, дээш өргөхөд өдрийнх шиг хүнд биш байлаа. “Шал дэмий юм, ямар нэг хэрэгтэй хэрэггүй шилэн бөмбөлөг л байна” – гэж тэр сэтгэл нь хачин хөнгөрөн бодсон боловч бөмбөлгийг байранд нь буцааж тавьсангүй, харин босч, түүнийг цээжиндээ наав. Тэгснээ гэнэт нэг санаа төрлөө. Тэр өлмий дээрээ сэмхэн гэтэн холдоод том чулуу авч ирэв. Дахин бохирч суугаад, бөөрөнхий юмны боодлыг хуу татаж, оронд нь чулуугаа боогоод, Гэндальфын баруун гарын дэргэд тавив.

Эцэст нь өвдөгнийх нь дэргэд хэвтэж байгаа бүдэг хар өнгөт бөмбөлөг рүү харав. Пин түүнийг аваад, цувны хормойдоо санд мэнд ороож, өөрийнхөө байр руу эргэх гэтэл Гэндальф нойрон дундаа хөдөлж, харь хэлээр ямар нэг юм бувтнав. Түүний гар боодолтой юмыг тэмтэрснээ санаа алдаад дахин нам жим болов.

“Усан тэнэг минь, нэг л наалдвал сална гэж байхгүй шүү! Одоохон буцааж байранд нь тавь!” – гэж өөртөө сонсдохооргүй хэлэв. Гэвч өвдөг нь чичирч, шидтэн рүү дахин ойртож, боодолтой юмыг солих зүрх хүрсэнгүй. “Чадахгүй нь, би түүнийг сэрээчихнэ. Эхлээд тайвшрах хэрэгтэй. Тэгээд хэрэггүй ч байсан хамаа алга, ингэж зовсныхоо төлөөсөнд нэг хараадахъя. Гэхдээ энд биш!” – гэсэн бодол толгойд нь зурсхийв. Тэр өөрийнхөө өвсөн дэвсгэрээс холгүйхэн ногоон довцог руу гэтлээ. Дэнжийн цаанаас гэнэт сар цухуйв.

Пин сууж, өвдгөө нийлүүлэн хөлөө жийгээд, бөмбөлгийг дээр нь тавьж, яг л тавагтай хоол хулгайлсан өлсгөлөн жаал шиг цувныхаа хормойг яраад бөмбөлгийг харлаа. Харанхуй болж, чих нь янгинаад явчихав. Эхлээд бөмбөлөг бүдэг хар, дараа нь сарны гэрэлд гялалзсан тас хар болсноо дотроосоо аажмаар гэрэлтэж, нүдийг нь өөрийн эрхгүй татаж эхлэв. Бөмбөлөг гэнэт дүрсхийн асч, эргэлдэж эхлэв. Үгүй ээ, дотор нь хүрэн улаан галан хуй эргэлдсэнээ гэнэт унтрав. Хоббит дуу алдан ёолж, бөмбөлгөөс салах гэж оролдсон боловч хий дэмий атиралдан, түүнийг хоёр гараараа тас атгасаар байлаа. Тэр бөмбөлөг рүү улам улам наалдан бөхийж, дараа нь хөшөө мэт хөдөлгөөнгүй болон, уруул нь дуугүй өмөлзөв. Тэр битүү хашгираад

түрүүлгээ харан уналаа.

Аймшигтай хашгирсан учир харуулууд дэнж рүү харайн ирж, хуаран хоромхон зуурт бүхэлдээ сэрэв.

- Аа муу золгүй хулгайч! – гэж Гэндальф хэлээд болор бөмбөлөг дээр нөмрөгөө яаран хаяв:

- За, Пин минь, битгий л үхчихээрэй дээ! – гээд тэр хөл гараа тэрийлгэн хөшсөн, нүд нь тэнгэр өөд хөдөлгөөнгүй ширтэж буй хоббитын дэргэд өвдөг сөхрөн суув:

- Чи юу хийж амжих нь энэ вэ, бид одоо юуг хүлээх болох нь вэ? – хэмээн дуу алдав.

Шидтэний нүүр эрс өөрчлөгдсөн байлаа. Тэр Пиний гараас барьж, амьсгалыг нь чагнаж үзээд, дараа нь алгаараа духан дээр нь дарлаа. Хоббитын бие салганан чичирч, зовхи нь хаагдав. Тэр нэгэнтээ хашгираад, өндийн сууж, дээрээс нь тонгойн ажиглаж байгаа сарны гэрэлд цайвартан харагдах нүүрнүүд рүү гайхан гөлрөв. Тэгснээ:

- Энэ бол чиний тоглох тоглоом биш ээ, Саруман! Бид одоо түүний хойноос элч илгээлээ. Ойлгов уу, тэгж дамжуулаарай! – гэж чанга гэгч хашгираад, ухасхийн босч, зугтаах гэхэд нь Гэндальф түүнийг барьж авлаа.

- Перегрин Молтогчин! Эргээд ир!- гэж Гэндальф дуудахад мань Хоббит тайвширч, найдвартай, чанга гарын тэврэлтэд шигдэн наалдав.

- Гэндальф, чи юу! Намайг уучлаарай, Гэндальф!

- Уучлах гэнэ ээ? Эхлээд яах гэж ингэв гэдгээ хэлэхгүй юм уу?

- Би юу... бөмбөлгийг авч яваад дотор руу нь харсан. Тэгээд маш аймшигтай юм харсан, салж болохгүй байсан. Тэр гарч ирээд намайг байцаасан, тэгээд над руу хараад байсан... тэгээд ... өөр юу ч санахгүй байна.

- Ингээд өнгөрөхгүй шүү - гэж Гэндальф ширүүн хэлээд: - Чи чухам юу харсан, тэр чамаас юу асуусан, чи юу гэж хариулсан бэ?

Пин нүдээ аньж, чичигнэн чичирч байсан боловч нэг ч үг дуугарсангүй. Бүгд түүн рүү дуугүй харж байлаа. Мерри л харж чадсангүй, нүүрээ буруулав. Гэндальфын царай ширүүн хэвээрээ байлаа.

- Хариул! – гэж тэр тушаав.

Пин эхлээд бөглүү, сонсогдохгүй дуугаар ярьж эхэлсэн боловч, үг үгээр улам тодорч, энгийн ярилаа:

- Би харанхуй тэнгэр, өндөр, хөрөөний ир шиг шүдтэй цамхаг харсан, бас жижигхэн жижигхэн одод байсан. Аль дивангарт, алсын алсад байсан юмнууд шиг мөртлөө тод харагдаж байсан. Одод нэг жирвэлзэж, нэг унтарч байсан. Ямар нэг далавчтай мангасууд

оддыг хааж байх шиг санагдсан. Цамхгийн дээгүүр асар том сарьсан багваахайнууд эргэлзэж байсан. Тоолоход ес байсан. Нэг нь шууд над руу нисч, улам л томроод байсан. Тэр их аймшигтай... үгүй ээ, үгүй! Энэ тухай ярьж болохгүй.

Би тэр аймшигт үзэгдлээс салахыг хүссэн, гэтэл тэндээс тэр мангас нисч ирээд бөмбөлгийг хаачихаад алга болсон. Дараа нь тэр гарч ирсэн. Үг яриагүй, зөвхөн над руу хараад байсан, гэхдээ юу хэлж байгаа нь надад ойлгомжтой байсан.

“Чи эргээд ирэв үү? Яагаад ийм удаан чимээгүй байсан бэ?”

Би хариулаагүй. Тэр: “Чи хэн бэ?” гэж асуусан, би дуугүй л байсан, тэгэхэд бие тэсэхийн аргагүй их өвдсөн, тэсэхээ байгаад “Хоббит” гэж хэлсэн. Тэр гэнэт намайг харах шиг болсон, тэгээд хөхрөөд байсан, тэрний хөхрөх нь тэсэхийн аргагүй тамлалт байсан. Би байдаг хүчээрээ эсэргүүцсэн. Тэр: “Жаахан хүлээж бай. Удахгүй дахиад уулзана. Одоохондоо Саруманд “Энэ бол чиний тоглох тоглоом биш ээ, Саруман! Бид одоо түүний хойноос элч илгээлээ. Ойлгов уу, тэгж дамжуулаарай!” гэсэн. Тэгээд дахиад л аймшигтай хөхөрсөн, бүх шөрмөсийг минь бахиар татаж байгаа юм шиг, ямар ч үхлээс аймшигтай... Үгүй ээ, үгүй, энэ тухай ярьж болохгүй. Өөр юу ч санахгүй байна.

- Миний нүд рүү хар! - гэж Гэндалф хэлэв.

Пин түүний нүд рүү цавчлах ч үгүй харж байв. Тэсэхийн аргагүй удаан чимээгүй байлаа. Дараа нь шидтэний царай зөөлөрч, нүүрэнд нь инээмсэглэл тодрох шиг болов. Тэр Пиний толгойг илэв.

- За за! Зүгээр. Чи сэргэлээ! Чиний нүд худлаа яриагүйг би харж байна. Тэр чамтай удаан ярьж дээ. Чи тэнэг байсан, тэнэг чигээрээ үлдлээ, гэхдээ чи чин шударга тэнэг, Перегрин Молтогчин минь. Чиний оронд чамаас ухаантай нэгэн байсан бол энэнээс ч долоон доор юм болох байсан байж ч мэднэ. Гэвч нэг юм санаж яв! Чамайг болоод чиний найз нарыг энэ удаа азтай тохиолдол аварлаа. Харин дараагийн удаа аврахгүй шүү. Тэр чамайг олигтойхон байцаасан бол чи тамлалтыг даалгүй мэддэг бүхнээ хэлэх байсан. Тэгээд бид бүгдээрээ зүйл дуусах байлаа. Гэвч аз болоход тэр яарсан байна. Зүгээр нэг мэдээлэл тэрэнд хангалтгүй санагдаад, тэр чамайг нэн даруй барьж аваачаад хар цамхагтаа яаралгүй тарчлаан тамлаж, бүгдийг мэдэх гэж боджээ. Боль, чи битгий татганаад бай! Мэргэдийн хэрэгт хамраа шургуулсан бол сүүлээ битгий хавч! За яахав, энэ удаа чамайг өршөөе. Бүх юм тийм ч муугаар эргэсэнгүй, эргэж болох л байсан.

Тэр Пинийг өвсөн дэвсгэр дээр нь хүргэж өгөв. Мерри найзынхаа дэргэд суулаа.

- Тайван хэвтээд, унтахыг хичээ, Пин! - гэж Гэндалф хэлээд: - хойшид миний үгэнд итгэж бай! Дахиад ингэж загатнавал надад хэлж бай, анагаах эм байдаг юм. Ямар ч тохиолдолд миний тохой доор чулуу тавих гэж бүү бод! Хоёулаа байж бай, энэ та хоёрт ашигтай.

Шидтэн нөхөд дээрээ очиход тэд Ортханкийн чулууны дээрээс харж, бодолд автацгаав.

- Гай зовлон шөнө дунд ирж, биднийг гэнэдүүллээ. Бид гайхамшгаар аврагдлаа! – гэж

Гэндальф хэлэв.

- Хоббит яах бол? - гэж Арагорн асуулаа.

- Тэр зүгээр байх гэж бодож байна. Түүнийг удаан тамлаагүй байна. Хоббитууд гайхалтай тэсвэртэй ардууд. Туулж өнгөрүүлсэн аймшгийн дуртгалыг ч гэсэн хөнгөхөн мартдаг. Арай л хурдан мартдаг. Арагорн, чи энэ чулууг хадгалахгүй биз? Үүнийг хадгалах аюултай нь мэдээж, гэвч...

- Хэн бэ гэдгээс л шалтгаална. Энэ чулуунд хууль ёсны эзэн бий. Энэ чулуу бол Элендилийн эрдэнэсийн сангаас авсан Ортханкийн палантир, үүнийг Гондорын вангууд энд тавьсан юм. Эцсээ үзэх цаг ирж байна. Миний палантир надад хэрэг болж магадгүй л юм.

Гэндальф Арагорн руу хараад, боодолтой чулуугаа түүнд гүнээ мэхийн гардуулав:

- Үүнийг хүлээн авна уу, эзэнтэн минь! Ирэх өдрүүдийн баталгаа болог! Гэвч чамд өгөх зөвлөгөөг минь бас хүлээн авна уу. Цагийг нь болтол түүнд битгий хараарай! болгоомжлоорой!

- Би энэ олон жилийн сорилтод ядаж ганц удаа яаруу, нэр алдарт дуртайгаа харуулж байсан гэж үү? – гэж Арагорн асуув.

- Нэг ч удаа үгүй. Замын эцэст бүү замаасаа гажаарай. Наад зах нь нууцалж хадгал. Шөнийн адал явдлын гэрч та нар ч гэсэн чулуу хаана хадгалагдаж байгааг хоббит Перегринд санамсаргүй илчилж болохгүй! Тэр түүнийг дахиад татах болно. Пин бүр Изенгардад үүнийг барьж байсныг би хараагүй юм. Би Сарумантай ноцолдоод юун чулуу болохыг нь анзаараагүй юм. Дараа нь оньсого таахад ойрхон байсан боловч ядарч, найр хүрээд унтчихаж. Одоо л бүх юмны учрыг оллоо!

- Тийм ээ, ямар ч эргэлзээ алга, одоо Изенгард, Мордор хоёрын хооронд яаж холбоо барьдаг байсан нь ойлгомжтой боллоо, өөр олон юмны учир олдлоо – гэж Арагорн хэлэв.

- Манай дайснуудын хүч чадал дэндүү аймшигтай юм, тэдний сул дорой нь ч бас дэндүү юм!
- гэж Теоден хэлээд: - Хар санаа хар толгойдоо гэж эртнээс ярьж ирсэн юм даа.

- Ихэнх тохиолдолд тийм байдаг, гэхдээ энэ удаа бидэнд дэндүү их аз тохиолоо. Хоббитын энэ үйлдэл намайг аймшигтай том алдаа гаргахаас сэрэмжлүүлээ. Би бүр энэ чулууг өөрөө судалж, өөр дээрээ турших гэж бодож байсан юм. Хэрэв тэгсэн бол агуугийн агуу их шидтэнтэй халз тулах байжээ. Гэтэл би тийм сорилтод бэлэн биш, угаасаа ч миний хийх ажил биш. Гэвч би түүний эрхэнд орохгүй байлаа ч гэсэн тэртэй тэргүй танигдах байсан, энэ бол бидэнд халтай. Цаг нь болоогүй байхад ил гарч болохгүй.

- Миний хувьд бол яг болчихоод байна - гэж Арагорн хэлэв.

- Хараахан болоогүй. Одоохондоо дайсан төөрөлдөж байх нь бидэнд ашигтай. Сауроны зарц чулууг одоо Ортханкт байгаа гэж бодож байгаа, яагаад болохгүй гэж? Тэгэхлээр хоббитыг

тэнд хорьсон байна. Саруман илүү их тамлахын тулд хоббитыг хүчээр шидэт толинд харуулсан. Тэрэнд хоббитын дуу, царай одоо танил болсон, тэр одоо золиосоо хүлээж байгаа –тэрний алдаа одоохондоо илрэхгүй. Гэвч бид яагаад цагийг хоосон өнгөрөөгөөд байгаа билээ? Бид дэндүү назгай байж. Хурдхан замдаа гаръя! Изенгардын хажууханд саатаад байх шаардлага байхгүй. Би түрүүлж явна, Перегрин Молтогчинг би авч явна. Одоохондоо тэр унтахгүй.

- Надтай хамт Эомер болон арван дайчин яваг. Бусад нь Арагорнтой байдаг хурдаараа давхиг – гэж Теоден хэлэв.

- Тэгсэн ч болно. Хамтдаа ч байна уу, тусдаа ч байна уу Хельмагийн хавцал руу давхицгаа! – гэж Гэндальф зөвшөөрлөө.

Яг энэ мөчид тэднийг асар том сүүдэр нөмрөн авч, тод саран гэнэт алга боллоо. Дайчид дээрээс нь ирэх цохилтоос хамаалж байгаа мэт гараараа толгойгоо халхлан газарт наалдав. Тэднийг сохор айдас хүлж, ясанд нь хүртэл хүйт оргижээ. Арай гэж зориглон дээш харахад хар үүл мэтээр сарыг хаасан аварга том далавчит амьтан үзэгдэв. Тэр тэдний дээгүүр нэг тойроод хойт зүг рүү хурдлан одов. Түүний зам дээрх одод бүдгэрч байлаа.

Ристаничууд хөл дээрээ боссон боловч хөдлөх тэнхэл алга байв. Гэндальф чанга зангидсан нударгаа буулгаад, далавчит мангасын араас харж байв.

- Хар үхээр! – хэмээн тэр хашгираад: - Мордорын элч! Сауроны мэдээч! Хар үхээрүүд их мөрнийг даваад иржээ! Давхиад байгаарай, үүр цайхыг хүлээх хэрэггүй! Хоцорсныгоо ч хүлээх хэрэггүй! давхиарай!

Тэрбээр Аянгыг дуудаад ухасхийн гүйв. Арагорн түүнд хурдан бэлдэхэд нь тусаллаа. Гэндальф Пинийг шүүрэн авч тэврээд:

- Энэ удаа чи надтай хамт явна. Аянгад илүү ачаа юу ч биш - гэв.

Мөнгөн хөлөг нь аль хэдийн ирчихсэн түүнийг хүлээж байлаа. Гэндальф хөнгөн үүргэвчээ мөрөн дээрээ хаяад, мориндоо үсрэн мордож, нөмрөгөөр нь хучсан Пинийг Арагорны гараас авлаа.

- Баяртай. Битгий сагаараарай! – гэж тэр хашгираад: - Аянга минь, урагшаа! – гэхэд сайхан мөнгөн хөлөг толгойгоо нэгэнтээ бардмаар өргөн хаялаад, саглагар өтгөн сүүлээ сарны гэрэлд мөнгөрүүлэн сэгсэрч, газраас тасрах мэт дүүлснээ уулсаас буух умрын салхи мэт довглон одов.

- Таатайхан бөгөөд тайванхан шөнө байлаа даа! Азтай зарим нь ч азтай байх юм аа! Түүний нойр нь хүрэхгүй байсан, унтаа ч үгүй, Гэндальфтай хамт явах сан гэж хүсээд нойр нь хүрээгүй юм. Тэгээд л яваад өглөө! Тэр чулуужаад энд үлдэж хойч үеийнхэнд сургамж болох байсан шүү дээ- гэж Мерри Арагорнд хэлэв.

- Хэрэв тэр биш, чи Ортханкийн чулууг барьж авсан бол өөрийгөө гарамгай баатар гэж

харуулах байсан гэж бодоо юу? Би эргэлзэж байна! Нэг үгээр хэлэхэд энэ удаа чи азгүйтлээ. Чамайг би авч явна. Хурдан юмаа бэлтгэ, Пин юм хүм мартсан байвал аваарай. Түргэл!

Аянга харанхуй талаар хурдалсаар байлаа. Түүнийг шавдуулах ч хэрэггүй, жолоог нь залах ч хэрэггүй ажээ. Нэг цаг ч болоогүй байхад тэд Изенгардын гармыг өнгөрч, дээр нь жаднууд хатгасан өндөр саарал хиргисүүрийн хажуугаар гарлаа. Пин бага багаар сэргэсээр байв. Дулаацаж, нүүрийг нь сэнгэнэсэн сэргэг салхи илбэж байв. Гэндальф дэргэд нь явж байна. Чулуу руу татсан аймшиг, сар хаасан муухай сүүдэр бүгд ард хоцорч, хар дарсан зүүд юм уу уулын манан шиг санагдана. Тэр цээж дүүрэн амьсгаллаа.

- Чамайг эмээл ч үгүй, хазаар ч үгүй явдгийг чинь мэдээгүй юм байна, Гэндальф!

- Ерөнхийдөө би эльфүүд шиг эмээл, хазааргүй явдаггүй, гэвч Аянга эмээл хазаарт дургүй, тэр хэнийг нуруундаа тээхээ өөрөө мэддэг, нэг тээсэн бол унагаахгүйн тулд анхаарал тавина. Өөрөө л зориуд үсрэхгүй юм бол унагаана гэж үгүй.

- Ямар ч хурдан юм бэ дээ, чихэнд л салхи хүүгээд байх юм, ямар ч зөөлөн давхидаг юм бэ! Бараг газар шүргэхгүй байна шүү дээ!

- Одоо хамгийн хурдан хөлгөөс ч хамаагүй хурдан давхиж байна. Аянгад энэ юу ч биш. Энд их өгсүүр газар, энхэл донхол ихтэй тал. Гэвч оддын доороос Цагаан уул яаж ойртож байгааг харж байгаа биз дээ! Тээр харагдаж байгаа гурван шовх оргилтой уул бол Гурваншовх. Уулзвар хүртэл ойрхон, тэндээс Хавцлын ам хүртэл хэдхэн харайгаад л хүрнэ. Хоёр хоногийн өмнө тэнд аймшигт тулалдаан болсон шүү дээ.

Пин удаан дуугүй явсангүй. Гэндальф хамар дороо харийн хэлээр ямар нэгэн дууны хэсэг аялсаар, бээр бээрээр зам хорж байгааг мэдэж байв. Эцэст нь шидтэн түүний мэддэг хэлээр бүхэл бүтэн шүлэг уншихад хоббит тасралтгүй исгэрэх салхин дундуур ялган сонсов:

Гурван гурвын есөн онгоцоор

Холын холоос хаад иржээ.

Хөлөг онгоцон дээрээ хаад

Холын нутгаасаа юу авчраа вэ?

Долоон гэрэлт од,

Долоон нүдэт чулуу,

Цасан цагаан зулзаган мод.

- Энэ чинь юун тухай шүлэг вэ, Гэндальф?

- Би эртний дуу шүлгүүдийг эргэн санаж байна, Хоббитууд тэдгээрийг аль эрт мартсан, мэддэг байсан цөөн хэдийгээ ч мартсан биз дээ

- Бид бүгдийг нь мартаагүй ээ, бас өөрсдөө олныг зохиосон. Харин чи одоо тэднийг сонирхох зав байхгүй. Харин энэ шүлгийг би хэзээ ч сонсч байгаагүй юм байна. Юун долоон од, долоон чулуу вэ?

- Эртний хаадын гэрэлт чулуу буюу палантирууд.

- Юун палантирууд?

- “Палантир” – гэдэг бол “холыг харагч” гэсэн утгатай. Ортханкийн чулуу бол тэдгээрийн нэг нь байгаа юм.

- Тэгэхлээр тэр чулууг... Дайсан огт хийгээгүй байж таарах нь уу?

- Дайсан ч биш, Саруман ч биш. Тийм ур ухаан Саруманд ч байхгүй, Сауронд ч байхгүй. Ер нь өрнөд хязгаарын хэнбугайд ч байхгүй. Палантируудыг Эльдамараас авчирсан, тэднийг Ноддорын эльфүүд хийсэн юм. Магадгүй, Феанор өөрөө ч хийсэн байж мэднэ. Энэ бол балар эртний бүтээл дээ, тэр цагаас хойш эрин зууны тоог ч алдсан. Гэвч Сауроны хар шид ертөнц дээрх бүх юмыг бузарлаж байгаа юм. Тийм ч учраас Саруман тэрэнд урвасан болохыг одоо л би ойлгож байна. Бидний ухаанаас давсан шинж чанартай зэвсэг тун ч аюултай. Гэхдээ Саруман ч өөрөө буруугүй биш л дээ. Тэр өөрийнхөө нууц зорилгын үүднээс эдгээр чулууг нуусан, Зөвлөлд энэ талаар амаа ч ангайгаагүй. Харин бид Гондорыг донсолгосон аян дайн болон өөр бусад дайн байлдаанаас болоод эртний палантирудын тухай бодохоо ч мартсан юм. Хүмүүсийн ой тойноос ч гэсэн бараг л арчигдсан болов уу. Бүр Гондорт ч гэсэн тэднийг санаж байгаа хүн цөөхөн, Арнорт цөөхөн дунаданчууд эртний домгийн нууцлаг үгсийг ойлгоно.

- Эртний хүмүүст тэдгээр чулуу яагаад хэрэгтэй байсан юм бол? - хэмээн Пин асуусан болгонд нь хариулж байгаад урамшин гайхахын зэрэгцээ энэ байдал удаан үргэлжлэх болов уу – хэмээн өөрөөсөө асуув.

- Нүдэнд харагдахгүй юмыг харж, алс холоос чимээгүй ярихын тулд – гэж Гэндалф хариулаад: - Тэд Гондорын бүрэн бүтэн байдлыг нууцаар хамгаалж байсан юм. Тэдгээр чулуунуудыг Минас-Анор, Минас-Итил, нэвтэршгүй Изенгардын дундах авгагдашгүй Ортханкт байрлуулсан юм. Хамгийн гол чулуу нь одоо балгас болсон Осгилиат дахь оддын оргил чулуу байсан юм. Бусад гурвыг нь алс умар зүг рүү аваад явчихсан. Тэдний нэг нь Арнорын нийслэл Ануминаст, нөгөө нь Амон-Сулд, Салхин уулын цамхагт, гол чулуу буюу Элендилийн чулуу нь Цамхагт ууланд байсан, тэндээс Митлонд болон Хавирган сарны булан дахь мөнгөлөг хөлгүүд харагддаг гэж би Элрондоос сонссон.

Палантирууд бие биетэйгээ харилцах дуудлын дохиотой байсан, тиймээс ямар ч үед Гондорын аль ч хязгаарт болж байгаа үйл явдал Осгилиатын нүдэнд ил байдаг байжээ. Ингээд ганцхан Ортханкийн хадан уул цаг хугацааны түрэлтэд тэсч, тэндхийн цамхагт палантир хадгалагдан үлджээ. Харахад аль дивангарт улирч одсон цаг үе болон үйл явдлуудын өчүүхэн үзмэр юм. Энэ нь Саруманд багадсан нь бас муугүй хэрэг. Тэр улам гүн харсаар байгаад эцсийн эцэст Барад-Дурыг харсан байна. Тэгэнгүүтээ баригдчихжээ!

Сураггүй алга болсон Арнорын чулуу болон Гондорын чулуунууд хаана байгааг хэн мэдэх билээ? Газарт булаатай байгаа юм уу, гол мөрний ёроолд живээтэй байгаа юм уу бүү мэд. Тэр хоёрын нэг нь яаж ийгээд Сауронд олдож, тэрний зэвсэг болжээ. Бодвол Минас-Итилийн чулуу биз, тэр цайзыг Саурон аль эрт эзэлсэн, тэгээд цайзыг аймшгийн орон болгон хувиргаж, Минас-Моргул гэж нэрлэсэн юм.

Одоо бол Саруманы тэнэмэл нүд яаж олзлогдож, яаж хавханд орсныг мэдэхэд төвөгтэй биш. Тэр цагаас хойш түүнийг яаж далдуур илбэдэн хөөргөж, яаж айлгаж байсныг мэдэхэд ч төвөггүй. Тэр өдрөөс өдөрт, жилээс жилд шидэт толинд наалдсаар Мордорын хараан дор Мордорын зааж өгснийг хийж иржээ. Ортханкийн нүдтэй чулуу Барад-Дурын шидэт толь болсон байна. Өнөө үед тэр толь руу харсан бүхэн юунд ч дийлдэшгүй сэтгэлийн хатан зориггүй л бол Хар эзэнд хэрэгтэй юмыг л харна. Тэгээд тэрний олз болно. Тэр өөртөө яаж татдаг вэ! Би мэдэлгүй яахав дээ! Би одоо ч гэсэн өөрийнхөө хүчийг сорьж, палантирыг хар хүчнээс цэвэрлээд, далайн чанадах гайхамшигт Тирион хотын үеийг, Феанорын санаанд багтамгүй уран тансаг бүтэл, Цагаан модны цэцэг, Алтан модыг харуулж чадах уу, үгүй юу гэдгээ үзмээр л байна!

Гэндалф санаа алдаад дуугүй болов.

- Би энэ талаар юу ч мэдэхгүй байсан нь тоогүй, юу хийж байгаагаа ёстой төсөөлөө ч үгүй – гэж Пин хэлэв.

- Сайн мэдэж байсан, тэнэг юм хийж байна гэдгээ чи мэдэж байсан шүү дээ! Мэдэж байсан, өөрөө өөртөө хэлж байсан, тэгсэн мөртөө өөрийнхөө үгэнд ороогүй. Би чамайг урьд нь сэрэмжлүүлээгүй нь зөвхөн одоо л энэ бүхнийг ойлгож байна. Хэрэв сэрэмжлүүлсэн бол чи өөрийгөө барьж дийлэхгүй байсан. Бүр эсрэгээр эргэх байсан! Сүүнд түлэгдээд тараг үлээх гэгчээр сайн зөвлөгөө хэрэг болно шүү.

- Ярих юу байх вэ! Одоо миний өмнө тэр долоон чулууг долууланг нь авчраад тавьсан ч би нүдээ чангахан аниад гараа халаасандаа лавхан хийнэ.

- Сонсоход таатай байна, тэгэхийн тулд л энэ бүхнийг ярьсан юм шүү дээ.

- Би бас нэг юм мэдэхийг хүсч байгаа... – гэж Пин эхэлтэл:

- Өршөөж хайрла! - гэж Гэндалф дуу алдаад: - Хэрэв чиний сониучирхсан болгоныг ярина гэвэл миний амьдралын үлдсэн өдрүүд гүйцэхгүй. Өөр юу мэдмээр байна тэгээд?

- Би юу? Тэнгэрийн эрхсийн нэрс, газрын амьтдын нэрс, Дундад газар, Дээд газар, Тэндхийн тэнгисийн түүхийг мэдмээр байна, ердөө ингээд л болоо – гээд Пин инээж: - гэхдээ яарах юм алга, жаахан хүлээсэн ч яахав. Би тэр хар сүүдрийн тухай асуусан юм... Чи: “Мордорын элч!” гэж хашгирсан. Юун элч? Тэр яах гэж Изенгард руу ирж байгаа юм бэ?

- Тэр бол далавчит хар морьтон, бөгж эзэмшигч хар үхээр байсан. Яах гэж гэв үү? Тэр чамайг аваад Барад-Дурт аваачих гэж ирсэн.

- Тэр намайг авах гэж ирээгүй биз дээ? Тэр намайг ...юу яасан гэж мэдэхгүй шүү дээ...

- Яагаад ч мэдэхгүй байсан. Барад-Дураас Ортханк хүртэл шууд явахад элбэг хоёр зуун бээр, хар үхээр хүртэл гурав дөрвөн цаг ниснэ. Гэвч Саруман орхуудын довтолгооны дараа чулуунд харж, өөрийнхөө олон нууц санааг аргагүйн эрхэнд мэдэгдсэн. Тэгээд л элч тэнд юу болоод байгааг мэдэх гэж ирсэн. Маргааш хоёр дахь нь нисч ирэх байх. Тэгээд Саруман хөлнөөсөө аргамжаатай шувуу шиг болно. Өөрийгөө худалдан авч тэр чадахгүй. Тэрэнд одоо чулуу байхгүй, тэрнээс чухам юу хүсээд байгааг ч тэр мэдэхгүй. Харин Саурон олзны хоббитыг тэр л нуугаад байна, чулууг ч нууж байна гэж бодож байгаа. Саруман бүх үнэнийг ярилаа ч гэсэн тэрэнд тус болохгүй. Изенгард нурсан, гэтэл тэр Ортханкт яагаад ч юм бүрэн бүтэн, амьд мэнд суугаад байдаг! Нэг үгээр хэлэхэд Саурон тэрнийг бослого гаргасан гэж үзнэ, тийм сэжиг авахуулахгүйн тулд тэр бидэнтэй сүлбэлдэх гэж яарсан юм. Одоо тэр яах нь ёстой оньсого. Ортханкт тэр есөн бөгжтөнөөс яаж ийгээд өөрийгөө хамгаалах байх, ямар ч гэсэн оролдоно. Аль нэг хар үхээрийг буулгаад далавчит унааг нь алах гэж оролдож ч магадгүй. Хэрэв тэр ингэж чадвал ристаничууд хар морьдоо сайн харж хамгаалах хэрэгтэй болно доо! Энэ бүхэн бидэнд ямраар эргэхийг би бас л мэдэхгүй байна. Дайсан Саруманд уурласандаа нэг хэсэгтээ барьц алдаж магадгүй. Эсвэл Ортханкийн үүдэн дээр би зогсч, ард нь хоббитууд байхыг харсан ч байж мэднэ. Элендилийн угсаа залгамжлагч амьд, надтай зэрэгцээд зогсч байхыг ч харсан байж болно. Хэрэв Ристанийн хуяг дуулга өмхий Амтыг хуураагүй бол тэр Арагорн гэж хэн бэ гэдгийг санана.

Энэнээс л би айгаад байна. Тиймээс л бид галаас гарч түймэр рүү орохоор хурдалж байгаа юм. Өөрөөр хэлбэл Аянга бид хоёрыг харанхуйн хязгаар руу авч яваа юм.

Пин дуугүй болж, хүйтэн салхинаас нуугдах мэт нөмрөгөн дотор шургалаа. Тэдний доогуур саарал тал урсан өнгөрч байна.

- Хараач! Бидний өмнө Вестфольдын хөндий байна. Зүүн зам руу явъя. Тээр тэнд байгаа сүүдэр бол Хавцлын хонхор, тэнд Агларонд болон Гялалзуур агуйнууд байгаа. Тэр талаар надаас бүү асуу. Гимлитэй уулзахаараа асуугаарай. Тэгээд богинохон асуултад ямар урт хариулт байдгийг мэдэж авна биз. Чи өөрөө энэ удаа үзэж чадахгүй, мөдхөн бид тэдгээрийг ардаа орхино.

- Юу гэсэн үг вэ, бид Хельмагийн цайзад бууна гэж би бодсон юмсан. Чи хаашаа ингэж яараад байгаа юм бэ?

- Минас-Тирит рүү, дайн эхэлчихээс өмнө хүрэх хэрэгтэй байна.

- Их хол уу?

- Жаахан хол оо, эзэн захирагч Теодений нийслэл хүрэхээс хоёр дахин хол, тэр хүртэл Мордорын элч нар нисч байгаа юм шиг шууд явах юм бол зуу гаруй бээр зайтай. Аянгын зам арай урт, хэн нь урьтаж очих нь вэ, харна даа. Үүрээр, гурван цаг орчмын дараа хаа нэг газар бууж амарна, Аянгад ч гэсэн амралт хэрэгтэй байдаг юм. Аль нэг ууланд. Эдорас хүртэл давхичих юм бол сайхан л байна. Унтахыг хичээ! Сэрэхэд чинь эорлингуудын ордны алтан дээвэр дээр өглөөн нарны туяа хугарч нүдийг чинь гялбуулна. Хоёр хоногийн дараа

Миндоллуин уулын бараан сүүдэр, Денэторын ордны цагаан ханыг өглөөн нарны туяанд гялалзахыг нь харах болно. Давхиарай Аянга! Давхиад бай, тэнгэр заяат морь минь, урьд өмнө давхиж байгаагүйгээрээ давхи! Чи энэ хязгаарт өссөн, чулуу бүгдийг нь мэднэ. Хамаг найдвар чамд л байна шүү!

Аянга толгойгоо хаялж, чангаар янцгааснаа байлдааны бүрээ сонссон мэт урагш дүүлэн нисэх мэт болов. Туурайнаас нь очис цацарч, харанхуй шөнийг зүсэн хурдаллаа.

Пин зүүрмэглэж, Гэндальф тэр хоёр морины чулуун хөшөөн дээр суугаад, шуугин исгэрэх салхин чимээн дор морин хөшөөний туурайнаас гал бутарч байх шиг санагдав.

Бүлэг 11

Смеагорлын тус

Эзэн минь, хоёулаа шаасан гадас, хадсан хадаас шиг сууж байна даа, цаашаа ч үгүй, наашаа ч үгүй - гэж Сэм хэлэв. Тэрбээр Фродогийн дэргэд уйтгартайгаар бөгтийн зогсоод бүрэнхий алс руу ширтэж байв. Тэр хоёр нөхдөөсөө оргон зугтсанаас хойш гурав хоног өнгөрчээ. Үнэндээ тэр хоёр өдөр, цагийн баримжаа ч алдаж, Дайсны хөндийн нүцгэн дэнжүүдээр нэг өгсч, нэг уруудаж, байн байн өөрсдийнхөө мөрөн дээр эргэн ирж байв. Ямар ч зөрөг жим байхгүй учраас нэг л газар тойрон эргэлдээд байлаа. Гэхдээ л тэр хоёр чиг зүг нь үл олоход атираа, нугачаат уулсын зүг аль болохоор барьж, ямар ч гэсэн урагш ахисаар байлаа. Уулсын хажуу нь эгц өндөр, дүнсгэр дүнсгэр хадан хясаанууд дүнхийж, бэлд нь амьдралгүй өмхий ногоон намаг хэсэг бусгаар үргэлжилжээ. Намгийн дээгүүр нэгээхэн ч шувуу эс үзэгдэнэ.

Хоббитууд хадан хясааны ирмэг дээр зогсон харахад тэртээ доор уулын нүцгэн саарал бэлийг үүлэнд тултал хөөрсөн өтгөн манан хучиж, шөнийн харанхуй намаг руу доошлон, намгийн бүдэг ногоон өнгө хар хүрэгтэж харагдана. Алс баруун зүгт жаргах нарны сулхан гэрэлд гялалзан харагдаж байсан Андуйн мөрөн одоо өнгөгүй мананд хучигдан үзэгдэхгүй болжээ. Мөрний цаана найз нөхөд нь, хүн амьтантай гэрэл гэгээт газар байгаа ч мань хоёр тэр зүг рүү бараг харахгүй явлаа. Тэр хоёр харанхуй шөнө наашилж байгаа, хөшингө хар утаанд дарагдсан зүүн өмнө зүг рүү л харж байв. Тэнд тэнгэр газар хоёрын заагт нэгэн тод улаан гал улалзана.

- Бид хоёр ч сайхан сууж байна даа, Дундад газар даяар очихыг хүсмээргүй ганцхан газар байдаг, гэтэл бид хоёр тэнд хүрэх хэрэгтэй байдаг! За яахав, хэрэгтэй л юм биз, гэтэл хүрч чадахгүй юм шиг байна даа. Бид хоёр жаахан төөрсөн шиг байна. Доошоо бууя гэхээр чихэндээ хүртэл өмхий намагт шигдэнэ. Түй, үнэрийг нь! – гээд Сэм нулимав.

- Үнэртэхгүй байхын арга алга даа - гэж Фродо хэлэв. Тэр хар хязгаарт сүүмэлзэж буй галыг харан зогсч байв.

- Мордор! – гэж тэр аяархан хэлээд: - Одоо яахав дээ, Мордорт очих ёстой юм бол очъё. Хурдхан л хүрэх юмсан, тэгээд л гүйцээ!

Хүйтэн салхи эвгүй муухай үнэр тээж байлаа.

- За за, суусан бол суугаа л биз, гэхдээ шөнөжин хясаан дээр зогсч хонолтой биш. Шөнийг өнгөрөөчихмөөр боломжийн газар олж хоночихоод өглөө гараад явчихъя.

- Гарна гэж үү? Ийм нүхнээс хаашаа гарах юм бэ? Өглөө боллоо гээд найдвар байхгүй биз. Төөрчихсөн байна гэж хэлээд байна шүү дээ, эндээс гарах зам байхгүй – гэж Сэм бувгнав.

- Үгүй дээ, зам олдоно, нэгэнт хувь заяа намайг ийшээ шидсэн бол хаагуур ч явсан хүрнэ. Харин тэр зам ямар байх нь өөр хэрэг. Удааширвал үхлийн аюултай гэж бидэнд хэлсэн байгаа. Саатах л юм бол дайсанд ашигтай. Гэтэл бид хоёр хаашаа ч гарч чадахгүй гацчихаад

байрнаасаа ч хөдөлж чадахгүй байна. Бид хоёрыг Хар цамхагаас хөтлөөд байгаа юм биш биз? Тэнэг хүн юу ч хийсэн буруу хийдэг. Би аль эрт, бүр Умардад явж байхдаа нөгөө хэдээсээ салаад Дайсны хөндийг тойрч, Мордорт уулын жимээр очих байсан юм. Гэтэл одоо юу болов? Чи бид хоёр одоо буцаж чадна гэж үү дээ? Андуины зүүн эргээр орхууд шиншилж байгаа. Тэгээд ч алдсан нэг өдөр бүхэн эргэж олодохгүй. Би их ядарчээ Сэм, үнэнийг хэлэхэд одоо яахаа ч мэдэхгүй байна. Идэх юм үлдсэн үү?

- Заавал үлдээнэ шүү дээ эзэн минь. Юу гэдэг билээ дээ, аа тийм путлиб шүү дээ. Өөр үзээд өгье гэсэн ч юм алга даа. Яг үнэндээ бол энэ хоолонд гомдвол нүгэл болно. Би анх энэ хоолыг амсахдаа ханаж цадтлаа иднэ гэж даанч бодоогүй. Харин одоо бол зүсэм хөх тарианы талх, гүрүүшиг пиво... за за, хагас гүрүүшиг пиво, тэгвэл ч харин нэг! Аяны тогоо, аяга таваг чирээд л яваад байдаг, ашиг нь юу байна надад? Гал ч түлэх боломжгүй, ядаж ногоо байтугай өвс ч чанах боломжгүй, яагаад гэвэл өвс нь байдаггүй!

Тэр хоёр буцаж налуугаар бугаад тухтай хонхор олж авав. Нар үүлэн цаагуур жаргаж шөнө боллоо. Тэр хоёр тун ч тааруухан унтав. Зүүнээс үлээх зэвүүн салхинд даарч, эргэн тойрноос чулуун ханаар хүрээлэгдсэн хонхорт эргэж хөрвөөн шөнийг өнгөрөөв.

- Та тэрнийг дахиж хараагүй юу, эзэнтээн? - гэж Сэм өглөөний хүйтэнд чичрэн байж саарал манан дунд нимгэхэн бингээ зажилж суухдаа асуув.

- Хараагүй ээ, юу ч хараагүй, юу ч сонсоогүй хоёр хонож байна.

- Би ч гэсэн. Бузар новш! Бүдүүлэг үг хэлсэнд уучлаарай! Гэвч бид хоёр тэр муу золгүй новшоос эцсийн эцэст салсан байж магадгүй. Хорлум гэнэ шүү! Дахиад тааралддаг юм бол би тэрэнд “хорлум” гэж хаана байдгийг үзүүлээд өгнө өө!

- Чи тэрнээр гараа бузарлахгүй дээ, тэр бид хоёрыг яаж олсныг мэдэхгүй юм, гэвч одоо мөр алдсан. Баярлаж л явъя хоёулаа. Хуурай хадан дээр мөр байтугай үнэр ч үлдэхгүй шүү дээ. Яаж ч үнэрлээд нэмэргүй биз.

- Тэгвэл ч сайн л байна. Мөн замын хань олдов оо!

- Тийм дээ, тэрэнгүйгээр болох байлгүй. За тэр ч ямай. Харин яаж эндээс буудаг юм билээ! Би бүр аль ч учраа олохгүй байна. Зүүн зүгээс бид хоёрыг мөрдөж байгаа, гэтэл бид хоёр тэгэхээс тэгэх гэж байгаа юм шиг тэдний нүдэнд ил байж байдаг. Бид хоёрын байгаа газар, тэндхийн харанхуй хоёрын хооронд өмхий намгаас өөр юу ч алга. Гэтэл бас тэндээс нөгөө бүхнийг харагч нүд хараад байдаг. Явж хайя, доошоо буух зам байж л таарна.

Тэр хоёр өдөржин гарц хайгаад олсонгүй орой болгов. Сэмийн хэлсэнчлэн доошоо буух зам байсангүй, байх ч шинж алга. Нам гүм, хов хоосонд байн байн жижиг чулуу өнхөрч, нүцгэн хөлийн чимээ гарах шиг сонсогдож байв. Тэгэхээр нь мань хоёр зогсч чагнахад ямар ч аниргүй, зөвхөн салхи л хад асга алгадан исгэрэх бөгөөд нөгөө чимээ хэн нэгэн хурц шүдээ ярзайлган агаар залгилж байгаа юм шиг санагдана. Дайсны хөндийн хойт үзүүр дэх атираат хадан уулсын амнаас аманд дамжин, урт урт ангалуудын хоорондох мянга мянган футын хясаа, цохионуудыг бараадан тэнэсээр байлаа. Хонхор хотгор газар тааралдах нь олширч, улам

л гүн болсоор Фродо, Сэм хоёр үл ажиглагдах бээр бээрээр ахисаар зүүн зүг рүү улам холдсоор байлаа. Тэгж явсаар мухар гүн хавцалд тулав. Хавцлын цаад талд хэрчсэн мэт эгц өндөр, арзгар саарал хясаа дүнхийнэ. Урагшаа явах газаргүй, баруун юм уу, зүүн тийш эргэх хэрэгтэй болов. Баруун тийшээ эргэвэл очих цэгээсээ холдон, тахиралдсан чулуун ангал руу улам гүн орно, зүүн тийшээ эргэвэл хавцлын ирмэг дээр гарна гэсэн хоёр сонголтын нэгийг хийх хэрэгтэй боллоо.

- Доошоо хавцал руу оръё, өөр гарц алга Сэм! – гэж Фродо хэлээд: - Энэ хавцал бид хоёрыг хааш нь гаргахыг харъя.

- Мөн ч гаргах байх даа! – гэж Сэм баргар царайлан бувтнав.

Хавцал ёроолгүй мэт үргэлжилжээ. Тэр хоёр хуурайшиж, хатангиршсан сийрэгхэн моддын дундуур орж ирлээ. Голдуу хус, хааяа нэг нарс байна. Ихэнх нь хатаж, үндэс нь үхсэн байлаа. Дорнын салхины хийсэн ажил бололтой. Нэгэн цагт энд бүтэн ой байсан шинжтэй боловч тавиадхан ярд яваад мод дуусч, хавцлын хязгаар хүртэл зөвхөн хожуулууд л үзэгдэнэ. Хавцлын ёроол нь дан хагарсан чулуугаар бүрхэгджээ. Мань хоёр хавцлын үзүүрт хүрээд Фродо гадагш шагайж харав.

- Хараач! Нэг бол бид хоёр доошоо гүн орсон байна, эсвэл хясаа нь газар руу суусан юм шиг байна. Түүрүүчийнхээс хавьгүй доор, хажуу тал нь тийм их эгц биш байна.

Сэм дэргэд нь өвдөг дээрээ суугаад, хавцлын цаад руу дургүйхэн харлаа. Дараа нь зүүн тийшээ хялайн харснаа:

- Тийм ээ, эгц биш юм байна, гэвч дээшээ биш, доошоо юм байна! Бүх амьтан бүгдээрээ нисч чаддаггүй, бараг бүх амьтан харайж чаддаггүй!

- Харайхад ч өндөр юм аа, ойролцоогоор арван найман сажин юм байна. Тэрнээс илүүгүй!

- Дажгүй л юм байна! Би өндөр дээрээс доошоо харах дургүй! Харах ч яая гэхэв хараа л биз, харайна л гэж байхгүй.

- За за, бид хоёр энэ рүү бууж чадах уу, үгүй юу гэдэг нь гол биш, заавал оролдоод үзэх хэрэгтэй гэдэг л гол нь. Харахгүй юу, хясаа нь огт өөр, налуудуу, ан цав ихтэй байна.

Хясаа үнэндээ налуу биш боловч доошоогоо нарийссан юм шиг байв.

- Хэрэв буух юм бол яг одоо эрт харанхуй болж байна. Аадар ч орох гэж байх шиг байна.

Зүүн талын уулсын дээгүүр харанхуй сүүдэр бүрхэн баруун тийш нүүж байлаа. Аадрын өмнөх салхи алсын аянгын чимээг авчирч байв. Фродо агаар үнэрлэж үзээд ихэд эргэлзсэн байртай тэнгэр өөд харлаа. Дараа нь бүсээ цувныхаа гадуур бүсэлж, үүргэвчээ үүрээд хясааны ирмэг дээр зогсов.

- Оролдоод үзье – гэж тэр хэлэхэд:

- Тэгвэл тэгэхээс дээ, гэхдээ би эхэлж үзнэ! - гэж Сэм дүнсгэр царайлав.

- Чи юу даа? Чамайг хадан хясаан дээгүүр мөлхөх дуртай гэж мэдэхгүй л юм байна шүү.

- Дургүй гээд яахав дээ. Эзэнтэн минь, ийм юман дээр толгойгоо ажиллуулах хэрэгтэй. Түрүүлж халтирах хүнээ түрүүлж оруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол дээрээс чинь халтирч унаад хоёулаа ум маани бадмэ хум!

Фродо нүдээ цавчиж ч амжаагүй байхад Сэм ирмэг дээр хөлөө унжуулан суугаад, өсгийгөөрөө тэмтрэн үзэж байв. Яаж ч бодоод тэр урьд нь ийм алхам хийж байгаагүй бөгөөд дэндүү тэнэг алхам байлаа.

- Чамайг даа! Сэм, бүү тэнэглэ! Чи зүгээр л амиа хорлоно шүү дээ, ядаж хаагуур нь буухаа эхлээд хардаг байгаа даа, буцаад! - гэж Фродо хашгираад Сэмийг хоёр суганаас нь татан ирмэг дээр гаргав. Тэгээд элэглэн хэвтэж, хавцал руу өнгийн хараад:

- Жаахан харъя, яарахгүйгээр болно. Үүгээр бууж болно, би лавтайяа чадна, чи ч гэсэн тайван, болгоомжтой хөдөлбөл чадна.

- Өөрөө өөрийгөө тайвшруулж байгаа юм уу? Юу ч харагдахгүй л байна шүү дээ. Бүрэнхий ч болчихлоо. Хөлөө ч тавих юмгүй, гараараа ч бариаад авах юмгүй ангал руу л нисгэчихнэ шүү дээ. Тэгэхээр яах вэ?

- Тэгвэл буцна даа.

- Хэлэх ч амархан л даа. Тэгснээс хүлээсэн нь дээр, өглөө яаж ийгээд гэгээтэй болно биз дээ.

- Үгүй шүү! Үгүй, хөл дээрээ зогсч байгаа цагт үгүй. Надад илүү цаг бүхэн, минут бүхэн дарамт болж байна! Би доошоо явлаа. Чи намайг эргэж ирэх юм уу, дуудах хүртэл томоотой сууж бай!

Тэр хясааны ирмэгээс барьж, болгоомжтой гулсч, хөлөөрөө тулгуур тэмтрэв.

- Оллоо! Баруун тийшээ өргөн юм байна, гараараа барихгүй зогссон ч болох юм байна, би цаашаа... – гэж тэр хашгираад чимээгүй болов.

Зүүн талаас нүүж ирсэн харанхуй тэнгэрийг бүрхлээ. Толгой дээр аянга нижигнэж, уулын оройгоор цахилгаан цахилав. Хүчит шуурга хүржигнэн шуурганы чимээний хажуугаар Норгордоос явж байх замд Намагт ууланд сонсогдсон тэр зүрх зүсэм зэвүүн муухай дуу хадав. Хоббитани ойд тэр дууг сонсоход цус царцах шиг болж байсан бол энэ хадан хясаануудын дунд зуу дахин аймшигтай байсан бөгөөд зүрх зогсч, амьсгал давчдаж байлаа. Сэм түрүүлгээ харан унав. Фродо гараа өөрийн эрхгүй хясааны ирмэгээс авч хоёр чихээ таглаад, найган ганхаснаа дуу тавин орилоод доош гулслаа.

Сэм түүний хашгирахыг сонсоод, өөрийгөө хүчлэн захирч, хясааны ирмэг рүү мөлхөв.

- Эзэнтээн, Эзэнтээн! Хэмээн хашгирсаар байсан ч хариу алга. Тэр дагжин чичирч, шүдээ

тачигнуулж байсан ч дахин:

- Ээ-зэ-эн-тээн! – гэж хашгирсаар.

Салхи түүний хашгирах дууг амнаас нь шүүрэн авч, хавцлын гүн рүү авч одсоор. Гэнэт сулхан дуугаар хариу хашгирах сонсдов:

- Би энд байна, битгий хашгир! Харин юу ч харахгүй байна.

Фродо тийм ч хол биш байсан ч дуу нь дөнгөж сонсогдох төдий байлаа. Тэр нисч унасангүй, гэдсээрээ хана даган гулсчээ. Энэ хэсэгт хясаа нэлээд налуу, нуруунаас нь хүчтэй салхи үлээж байсан учир хясаанаас ховхорсонгүй. Зүрх нь оволзон цохилж, нүүрээрээ хүйтэн чулуунд наалдав. Эргэн тойрон тас харанхуй, ийм өтгөн манан юм уу, эсвэл сохорчихсон юм болов уу? Фродо арайхийн амьсгаа авлаа.

- Буцаад ир! Буцаад ир! - хэмээн Сэм дээрээс тас харанхуйгаас хашгирсаар.

- Чадахгүй байна аа, юу ч харагдахгүй байна. Би яаж дээшээ гарах юм бэ? Хөдлөх ч тэнхэл алга.

- Юугаар туслах вэ эзэнтэн минь? Юугаар туслах вэ - гэж Сэм асуугаад хясааны ирмэг дээгүүр бүсэлхийгээ хүртэл цухуйн асуув: - Эзэнтэнд яагаад юу ч харагдахгүй байгаа юм бол? Ярихын аргагүй харанхуй байна л даа, тэгэхдээ л юу ч харагдахааргүй биш байна. Тэр өөрөө Фродог харж байлаа. Хадан хясааны хананд налдсан ганцхан саарал дүрс. Харагдах нь ч яахав, яаж хүрэх вэ?

Дахиад аянга нижигнэж, мөс мэт хүйтэн аадар мөндөртэй холилдон асгарч хоромхон зуурт эргэн тойронд саарал хөшиг татах шиг болов.

- Одоо би тань руу буулаа! – гэж Сэм хашгирсан боловч чухам яах гэж очихоо мэдээгүй байлаа.

- Болохгүй шүү! Хүлээж бай! - гэж Фродо хашгирав. Түүний дуу хоолой чангарчээ.

- Би одоохон арга бодъё! Би зүгээр болж байна. Бүү яар! Аргамжгүйгээр бүтэхгүй юм байна даа!

- Аргамж уу! - хэмээн Сэм санаа амарсан байдалтай санаа алдаад, өөрийгөө хилэгнэн зандарч гарав:

- Чамайг бүх мартамхайнуудад сургамж болгож хөлөөр чинь дүүжлэх хэрэгтэй! Чи ч ёстой сүг юм даа, Сэм Скромби! Хэдэн ч удаа Жихарь энэ үгийг давгаж байсан билээ дээ? Олс, олс!

- Битгий чалчаад бай л даа чи! Жихарийг тайван орхи! Чиний халаасанд аргамж байгаа учраас л чи өөрийгөө зандраад байгаа юм уу? Тэгэхийн оронд зүгээр л гаргаад ир л дээ!

- Халаасанд биш ээ, эзэн минь, үүргэвчинд байгаа! Хичнээн бээр газар тэрнийг үүрч яваа билээ, хэрэг болохоор нь мартчихдаг байна шүү!

Сэм үүргэвчнийхээ амыг гялс тайлж, тэмтрэн эрэв. Үүргэвчийн ёроолд үнэхээр бүтэн боодол торгомсог саарал лориэн аргамж байлаа. Фродо бараг бүрэн хэвэндээ орж, нүдний өмнөх харанхуй сарнисаар хараа орлоо. Түүн рүү унжин доошилж байгаа мөнгөлөг саарал өнгөт могойг хараад толгой нь эргэхээ болив. Фродо аргамжийн үзүүрийг барьж аваад бүсэлж, хоёр гараараа аргамжаас барилаа. Сэм арагш ухарч, хөлөөрөө хожуул руу жийж, Фродог байдаг хүчээрээ татав. Цаадах нь гарч ирэнгүүтээ хөдлөх ч тэнхэлгүй хэвтээд өгөв.

Аяндын нижигнээн холдсон ч бороо улам ширүүсэн шаагисаар байв. Хоёр хоббит хавцал руу мөлхөж ороод, хөмсөг хадны доогуур суусан ч төдийлөн тухтай байсангүй. Эргэн тойронд хөөсөрсөн горхи хүржигнэн, хясааны дээрээс борооны ус аварга том дээвэр дээрээс буух мэт нижигнэн буусаар байлаа.

- Би нэг бол тэнд ус балгаад мажийх байсан, нэг бол намайг зүгээр л үер хамах байсан. Чи аргамж авч гарсан нь ямар их аз вэ!

- Салан ангарай би аргамжаа арай эрт санасан бол бүр ч их аз байх байлаа. Эльфүүд завинуудыг ачаалахдаа завь бүрт нэг боодол аргамж хийсэн юм. Тэдний аргамж надад маш их таалагдсан болохоор би нэгийг нь үүргэвчиндээ хийчихсэн юм. Эльфүүд “Манай аргамжууд та нарт нэг бус удаа хэрэг болно шүү” гэж байсан, Хэлдар тэгж хэлсэн шиг санагдаж байна, эсвэл өөр хэн нэг нь ч юм уу. Ямар ч гэсэн үнэн хэлсэн байна.

- Би нэг боодлыг нь аваагүй минь харамсалтай, гэвч чи бид хоёрыг зугтаахад тийм юм санах сөхөө байгаагүй л дээ. Аваад гарсан бол одоо буухаас амархан юм байхгүй шүү дээ. Хэр урт юм бэ дээ?

Сэм аргамжаа алдалж үзээд:

- Тав, арав, хорь, за гуч орчим тохой юм байна даа.

- Байж болмооргүй юм! - гэж Фродо дуу алдав.

- Тийм шүү! Байж болмооргүй юм тэдэнд их бий. Энэ эльфүүд гэдэг гайхамшигтай ард түмэн дээ! Харахад нарийхан, зөөлхөнөөс зөөлхөн, тэгсэн мөртөө ямар бөх эд гээч вэ. Боодол нь алганд багтана, ямар ч жин байхгүй. Гайхамшигтай ард түмэн, өөрөөр юу гэхэв дээ!

- Гучин тохой! Хүрэх юм шиг байна аа. Аадар шөнө зогсох юм бол би буух гээд үзье.

- Бороо ч бараг зогслоо л доо. Харин харанхуйд дахиад саяных шиг юм болвол яана! Ямар муухай чарласныг санаж байна уу? Миний чихэнд одоо ч гэсэн янгинаж байна. Хар морьтнууд мөн нь гарцаагүй, тэд нисч чаддаггүй байсан, одоо нисээд сурчихсан бол яана? Энэ нүхэнд өглөө болтол хэвтсэн нь дээр биз дээ.

- Хар цамхгаас намаг дээгүүр давуулан дурандаж байгаа цагт амарч хэвтэх газар ч энэ биш ээ.

Энд нэг ч минут илүү байж болохгүй!

Фродо ингэж хэлээд босч, хясааны ирмэг рүү очоод доош харлаа. Дорно зүгт тэнгэр гэгээрч, хар үүлний сүүлчийн тасархайнууд тэнгэрээр мөлхөж байна. Аянга аадарт хар үүл одоо Андуины хөндийг аадар, аянга хоёроор нүдэж гүйцээд, Минас-Тиритийг заналт хар сүүдрээрээ хучин, Цагаан уулын оргилуудыг халхалж байв. Тэр үүл Гондорын нутгаар удаан нөмрөн өнгөрч, Ристанид хүрээд тэгш талаар баруун зүг довтолгож яваа морьт дайчдын харааг хааж байлаа. Харин энд хоосон хадан уулс, өмхий намгийн дээгүүр үдшийн тэнгэрийн хөх зурвас татаж, бүдэгхэн цайвар одод дүүжлээтэй сарыг тойрсон өчүүхэн цоорхойнууд шиг харагдана.

- Нүд юм харж байх ямар сайхан юм бэ, би ч цахилгаанаас ч юм уу өөр бүр ч муу юмнаас болоод сохорчихлоо л гэж бодсон шүү - гэж Фродо хэлээд гүнээ санаа алдаж:

- Гэнэт аргамжийг харахад, гэрэлтэж байх шиг санагдсан шүү.

- Тэр үнэн, харанхуйд мөнгөлөг өнгөөр гялалздаг юм байна лээ, би урьд нь мэдээгүй, яаж ч мэдэх билээ, үүргэвчийн ёроолд хэвтэж л байсан юм чинь, ямар идэх юм нэхсэн биш – гэж Сэм өгүүлээд:

- Харин та хясаа руу буух гэж тэсч ядаад байгаа юм бол яаж бууя гэж бодож байна? Гучин тохой гэдэг чинь цаанадаж арван найман сажин гэсэн үг. Хэрэв та өндрийг тооцоолохдоо алдаагүй бол ёроолд хүрнэ.

- Наад хожуулаа нэг үзээрээр нь бүсэл, Сэм! - гэж Фродо жаахан бодсоноо тушаагаад:

- Энэ удаад чинийхээр больё, чи түрүүлж буу. Би барьж байя, чи хөл гараараа хясаанаас зэрэг түлхэлт ав. Хананд наалдаад түр зогсч чадвал сайн, тэр хооронд би гараа амраана. Ёроолд буугаад аргамжаа тавь, би араас чинь бууна. Одоо би зүв зүгээр болсон.

- Тушааснаар чинь л больё - гэж Сэм дургүйхэн хэлээд: - За яахав, болох ёстой юмыг тойроод гарч болохгүй!

Тэр ирмэгт хамгийн ойрхон хожууланд аргамжнийхаа нэг үзүүрийг бэхлээд, нөгөө үзээрийг нь бүсэлж, дуртай дургүй эргэж харанхуй ангал руу оров. Буухад тийм ч аймшигтай биш байжээ. Аргамж түүнийг тогтоон барьж байсан төдийгүй зоригжуулж байх шиг. Гэхдээ л доошоо харах бүртээ өөрийн эрхгүй нүдээ аньж байлаа. Нэг эвгүй эгц хэсэгт хүрээд тэр хальтирч, мөнгөлөг аргамжин дээрээ дүүжлэгдэв. Гэвч Фродо бэлэн байсан тул аргамжийг нэгэн жигд, удаан хөврүүлж байв. Нэг үгээр хэлэхэд бүх юм санаанд оромгүй сайхан боллоо. Аргамж хүрэх болов уу, яах бол хэмээн айж байсан чинь тээр дороос “Боллоо!” хэмээн хашгирах үест Фродогийн гарт хангалттай урт аргамж үлдсэн байв. Дуу нь сайн сонсогдсон ч өөрөө харагдсангүй, эльфийн цув бүрэнхийтэй өнгө ижилсчээ.

Фродо арай удаан бууж ирэв. Тэр хожуулын уяаг шалгаад, найдвартай бүсэлж, дүүжлэгдэх үед доош нисэхгүйн тулд аргамжаа тохирох уртаар богиносгов. Сэмээс ялгаатай нь тэр нарийхан саарал аргамжид бүрэн итгэхгүй л байлаа. Гэлээ ч гэсэн найдаж болох юм байна гэдгийг

хоёр ч удаа мэдэж аваад бууж ирэв.

- За ингээд буучихлаа даа! Дайсны хөндий баяртай! Харин цаашаа яах болж байна даа? Хатуу газар, хөл дорх хад чулуугаа үгүйлэх юм биш биз дээ?

Гэвч Сэм хариулсангүй, тэр хадан хясааны ирмэг рүү гунигтай харж байв.

- Ээ муу сүг, Ээ муу сүг! Хайран аргамж минь! Чи нөгөө үзүүрийг нь хожуулд алдрахааргүй уясан, гэтэл одоо чи хаанаа буучихаад байна – хэмээн тэр өөрийгөө зэмлэж:

- Бид хоёр нөгөө муу үхээрийн муу Хорлумд шат үлдээчихлээ шүү дээ! Ингэхийн оронд шуудхан л “бид хоёр ийшээ явлаа, тийшээ явлаа” гээд захиа үлдээдэг байж. Бүх юм ийм амархан бүтэх нэг л жигтэй гэж зүрх минь хэлээд байсан юм аа!

- Зүгээр юм зүгээргүй байдаг, хэрэв бид хоёр аргамжтайгаа яаж буухыг мэдэж байсан юм бол намайг “сүг” гэж дууд, эсвэл Жихарыг өөр ямар ч үгээр дуудсан болно, хэрэв чадах юм бол буцаж дээшээ гараад аргамжаа аваад ир, би чамайг харж байя!

Сэм шилэн хүзүүгээ маажив.

- Үгүй дээ, толгойд юм орж ирэхгүй байна, бүү зэмлээрэй, гэлээ ч гэсэн аргамжаа орхимооргүй л байна даа! – гээд тэр аргамжийн үзүүрийг энхрийлэн илбэж, сэгсэрч үзээд:

- Эльфийн бэлэгнээс салахад харамсалтай байна, магадгүй Галадриэль өөрөө бидэнд зориулж сүлжсэн ч юм билүү. Галадриэль... – гэж тэр гүвгнээд, толгойгоо сэгсэрч, дээшээ өлийж хараад, салах ёс болгож хөнгөхөн, зөөлхөн, уян аргамжийг зөөлхөн дугтрав.

Гэтэл жинхэнэ хачирхалтай юм болж, аргамж ирмэг дээрх хожуулаас мултраад, Сэм гэдрэг бүтэн эргээд хөл дээрээ буухад мөнгөлөг саарал бүс түүнийг хөлөөс нь толгой хүртэл ороов. Фродо элгээ хөштөл инээлээ.

- Хэн тэр уяаг тайлчихдаг нь сонин байна, бас одоо болтол тэсч байсанд нь бас их баярлалаа. Би ч яахав Сэм намайг хөөдөхгүй гэж бодоод л тайван дүүжлэгдэж байсан!

- Уул хадаар урагш хойшоо авирч, буухыг би сураагүй байж болно эзэнтэн минь – гэж Сэм гомдонгүй хэлээд. Харин аргамж, уяаны талаар бол энэ чинь манай гэр бүлийн гар урлал байгаа юм, өршөөгөөрэй. Өвөг эцэгт маань элдав аргамж, олсны гар үйлдвэр байсан, тэрнийг Жихар биш, ууган хүү нь, миний авга ах Эндид өвлүүлсэн, харин элдэв уяа, зангилааны талд дээр бол дундад газар даяар биш гэхэд Хоббитан даяар намайг гүйцэх аавын хүү байхгүй шүү.

- Тэгэхлээр аргамж ямар нэг хурц ирмэгтэй хөмсөг хаданд үрэгдэж тасарсан байна даа.

- Тасарчихаж гэнэ ээ! – хэмээн өөрийнхөө төлөө биш, аргамжийнхаа төлөө бүр ч их гомдож аргамжаа өргөж үзүүлээд:

- Бүв бүтнээрээ л байна шүү дээ!

- Тэгэхлээр уяа тайлагдсан л байна даа

Сэм толгой сэгсрээд юу ч хэлсэнгүй, аргамжаа бодолхийлэн эвхэв. Тэгснээ:

- Эзэнтэн та юу л гэж бодно бод, харин би аргамж намайг дуудахаар өөрөө тайлагдаад ирсэн гэж бодож байна – гээд аргамжаа сурмаг эвхэж үүргэвчиндээ нандигнан хийлээ.

- Гүйгээд ирсэн юм байж - хэмээн Фродо зөвшөөрөөд:

- Гэхдээ ийм асууудал чухал биш, цаашаа яах вэ гэдгээ бодоцгооё. Одоохон шөнө боллоо. Ямар ч гоё одод вэ, энэ сарыг ээ!

- Харахад л сэтгэл сэргээд явчих юм, тийм биз? - гээд Сэм тэнгэр өөд харж:

- Тэнд эльфийн ямар нэг юм байна даа. Сар нь хүртэл өөг. Бид хоёр хоёр хоногийн турш үүлний цаана байгаа сарыг үзээгүй шүү дээ. Мөн ч сайхан гэрэлтэж байна даа!

- Тийм байна, гэхдээ л арай бүрэнхий байна. Хоёулаа маргааш хүртэл хүлээхгүй бол ийм гэрэлд хол явахгүй, намаг руу орчихно - гэж Фродо хэлэв.

Тэр хоёрыг замдаа гарахад бүр харанхуй болоогүй байлаа. Сэм хэдэн алхам яваад хясааны ирмэг рүү эргэж харав. Холоос харахад хавцал хөрөөний ир мэт харанхуй хар хадан хясаанууд байв.

- Аргамж маань тэнд зүүгээстэй үлдээгүй нь яамай, нөгөө муу үхээр бид хоёрыг хаашаа явчихав гэж шиншэлнэ. Өмхий нүцгэн улаараа хясаанаас хясаа руу харайж л байг!

Тэр хоёр хясааны ёроолоос холдож, саяны аадар борооны дараа нойтон болон овоорсон хайрга чулуун дундуур нэлээд эгц хажуу өөд өгсөв. Гэтэл хөл дор нь гэнэт гараад ирсэн ангал руу хариугүй уначих дөхөв. Тэр хонхор өргөн биш боловч харанхуйд дээгүүр нь харайх гэж санахын ч хэрэггүй, тэгээд ч түүний гүнд хаа нэгтээ горхи шоржигнож байв. Тэр ангал зүүн тийш, хойт зүг рүү эргэж, тэдний замыг найдвартай хаан, уул руу чиглэсэн байлаа. Харанхуй шөнө тэрнийг тойрч гарах аргагүй!

- Хажууг дагаж өмнө зүг рүү явъя. Аз таарвал хоног төөрүүлчихмээр хуурай булан юм уу, агуй ч олдож магадгүй – гэж Сэм санал гаргав.

- Магадгүй л юм, би их ядарчээ, арай ядан хөлөө зөөж байна, ядаж байхад нэлдээ чулуу. Аргагүйн эрхэнд хонох л болох нь. Ядаж нэг жим олддогсон бол унаж тустлаа явмаар л байна даа.

Хажуу дагаж нуранги чулуун дээгүүр явах амаргүй байв. Сэм хуурай булан ч, агуй олж чадсангүй. Доор нь нуранги чулуу, дээр нь дүнсгэр хадан хясаа. Эцэст нь тэр хоёр бараг сөхөрч унах дөхөн явсаар ирмэгээс холгой нэгэн асар том бул хаданд тулав. Хүйтэн чулуунуудын хооронд яаж ийгээд бүлээцэхийн тулд аль болохоор бие биеэ шахан суулаа. Нойр хүрч эхлэхэд эсэргүүцэх чадал байсангүй. Тод саран өндөрт гэрэлтэж, цайвардуу туяанд нь нүцгэн хадан цохионууд гялалзана.

- За за! чи жаахан унтаадах Сэм, миний хөнжлөөр давхарлаад хуччих. Би жаахан зогсоодхоё, зогсох ч гэж, ойр зуур жаахан алхаадхая – гээд даарсан шинжтэй цувныхаа захыг битүүлснээ гэнэт нам зогсч, бөхийнгөө Сэмийн мөрнөөс дугтарч:

- Энэ юу вэ? Хясаа руу хар даа!

Сэм харангуугаа исгэрэв:

- Өө за за! Санаж амжаагүй байтал гараад ирдэг байх нь, чамайг чөтгөр аваасай! Энэ чинь Хорлум л байна шүү дээ! Бид уулнаас буухдаа л тэрийг чулуу хөөлгөчихлөө гэж би бодож байсан юм! Та тэрнийг хараач! Аалз л байгаа биз дээ!

Сарны цайвар туяанд, харахад гилгэр, халтирамхай хадан ханаар жижигхэн хар амьтан дөрвөн мөчөө тэлэн мөлхөж байв. Тэрний нарийн мэдрэмжтэй, наалдамхай хорин хуруу хадан хананы өчүүхэн ч овгор товгор, ан цавнаас зууран тогтож, шавьжных шиг наалдамхай хөлөө найдвартай зөөн тавьж байх шиг харагдав. Тэр толгойгоо доош харуулан бууж байх бөгөөд, явах замаа үнэрлэж байх шиг. Байн байн урт нарийн хүзүүтэй том толгойгоо эргэлдүүлэх бөгөөд сарны гэрэлд хоёр нүд нь цийлгэр цайвар гэрэл болж нэг харагдан, нэг хаагдана.

- Тэр биднийг үзэж байгаа болов уу? – гэж Сэм асуув.

- Мэдэхгүй ээ, гэхдээ үгүй байхаа - хэмээн Фродо аяархан хариулаад:

- Эльфийн цув биднийг анд нөхдийн нүднээс ч гэсэн найдвартай нуудаг. Би л гэхэд чамайг сүүдэрт хэдхэн алхмын цаанаас үздэггүй. Тэр нар, сар хоёрын дайсан шиг санагдаж байна.

- Тэгвэл яагаад шууд наашаа мөлхөөд байгаа юм бол?

- Чимээгүй л дээ чи, Сэм! Тэр биднийг үнэрлэж мэдсэн байх. Бас эльфүүдээс дугуугүй сонсдог шиг байгаа юм. Тэр ямар нэг чимээ сонссон шиг байна. Бид хоёрын дуу хоолойг сонссон байх. Хоёулаа түрүүн галзуу юм шиг л орилж байсан шүү дээ. Дараа нь энд нэг минутын өмнө ямар ч шаардлагагүй чанга чанга чалчсан шүү дээ.

- Тэрэнд ч би бага зэрэг залхаж байна шүү, тэвчээд л байсан, тэвчээд л байсан, харин одоо ганц хоёр эелдэг үг солимоор байна. Тэрнээс зугтаагаад тэртэй тэргүй олдох л юм шиг санагдаад байна.

Тэгээд Сэм саарал юүдэнгээ нүүр рүүгээ буулгаад, хясаа руу чимээгүйхэн мөлхөв.

- Болгоомжтой! Тэрнийг битгий айлгаарай! Тэр харахад хариугүй амьтан боловч хамаагүй оролдвол дэмий юм болно! – гэж Фродо шивнэв.

Мөлхөө хар шавьж хясааны ханын дөрөвний гурвыг туулаад, ёроолд хүрэхэд тавин фут хүрэхгүй зай үлджээ. Хадны сүүдэрт нуугдсан хоббитууд түүнийг нүд цавчилгүй харж байлаа. Түүнд мөлхөхөд хэцүү болсон уу, сэрэмжилж болгоомжилсон уу, шуухтнаж, дараа нь хараал тавьж байгаа бололтой хорсолтой хуухирч, тэгснээ толгойгоо өргөн нулмих шиг

болсноо цааш хөдлөв. Тэрний сөөнгөтөж, хяхтнасан хоолой сонсогдлоо:

- Ахх, с-с-с! болгоомшштой, миний эррдэнэ! Яарвал даарна, хоёулаа хүзсүүгээ хугалахгүй сшшүү, тийм ээ, эррдэнэ минь? Тэгэхгүй сшшүү, ххоррлумм!

Тэр дахиад л толгойгоо өргөж, нүдээ цавчилснаа анив:

- Бид тэрнийг үзсэн ядна, өөдгүй, өөдгүй муу хулшшгар гэрэл с-с-с, тэр биднийг харж байгаа, эрдэнэ минь, тэр бидний нүд рүү шургаж байна.

Тэр бүр доошоо бууж ирэхэд сөөнгө бувтнаан нь бүр тод сонсогдов:

- Тэд нар хаана байна аа, тэрнийг минь, эрдэнийг минь хаана нуучихав аа? Тэр бол бидний эрдэнэ, бид тэрнийгээ санаж байна. Хулгайчууд, хулгайчууд, новшийн хулгайчууд. Тэд миний эрдэнэтэй хамт хаана нуугдачихав? Хараал идмэрүүд! хахаж үхмэрүүд!

- Тэр биднийг энд байгааг огт мэдэхгүй байх шиг, юун эрдэнэ яриад байгаа юм бэ? Энэ нөгөө...

- Ш-ш-ш! Тэр одоо бүр дэргэд байна, одоо тэр шивнээг ч сонсоно.

Үнэхээр ч Хорлум дахин нам жим болж, шөрмөслөг хүзүүн дээрх том толгой нь ийш тийшээ эргэлдэх нь чимээ чагнаж байгаа бололтой. Цийлэн нүд нь гялалзана. Сэм дуугүй болж, зөвхөн хуруу нь чичигнэж байлаа. Тэр хилэгнэж, ой гутсан харцаар тэр муухай шавьж руу харж байх зуур Хорлум шуухитнаж, шивнэсээр бүр доош буулаа.

Тэр хоббитуудын толгой дээр, арван хоёр футын зайд, хясааны ёроолын ирмэгт дүүжлэгдэв. Шууд унах юм уу, харайх хэрэгтэй байтал тэр юунаас зууралдахаа мэдэхгүй тийчэгнэнэ. Тэгээд хөлөөрөө доош буухаар эргэх гэж байгаад хаднаас ховхорч чангаар чарлаад өндрөөс унаж байгаа аалз шиг эвхрэн унав.

Сэм хоёрхон харайгаад Хорлумын дээрээс буусан боловч Хорлум огт сандарсангүй, Сэмийг нүдээ цавчиж ч амжаагүй байхад урт, уян гар хөл ороон авч, нялцанхай хуруунууд багалзуурт нь асч, хурц шүд мөрөнд нь шигдэв. Сэм зөвхөн тэрний нүүр рүү толгойгоороо мөргөж амжлаа. Хорлум шуухитнан нулимсан боловч, гар нь суларсангүй. Сэм ганцаараа явсан бол хэцүүдэхээр байлаа. Гэвч Фродо илдээ сугалан үсэрч ирээд хорлумын хэдхэн үснээс базаж, толгойг нь гэдрэг эргүүлэхэд хорсол дүүрэн цийлэн нүд нь арга буюу тэнгэр харлаа.

- Түүнийг тавь, хорлум! – гэж Фродо тушаагаад:

- Энэ бол Терн илд, чи үүнийг харсан шүү дээ, маш хурц шүү. Энэ удаа сийчүүлэхгүйг бод. Тавихгүй бол хоолойг чинь тасална.

Хорлум шалчийж, нялцгай шавар газарт шидсэн юм шиг болов. Сэм босч, хазуулсан мөрөө барьж үзээд, хөл доор нь уйлагнан мөлхөж буй арчаагүй дайсан руу ууртайяа харж зогсов. Ийм юманд гар хүрэх муухай билээ.

- Биднийг гомдоох хэрэггүй! Эдэнд биднийг гомдоох боломж бүү олго, эрдэнэ минь! Эд нар биднийг гомдоохгүй, сайхан санаатай, хөөрхөн хоббитууд биз дээ? Бид яагаа ч үгүй, зүгээр л байдгаараа байж байтал эд нар хөөрхий хулганыг барьдаг ховдог муур шиг л дээрээс гэнэт буучихсан. Үнэн биз дээ, эрдэнэ минь? Бид хөөрхий өнчингүүд, хорлум. Хэрэв бидэнтэй сайнаар харьцах юм бол бид маш их дуулгавартай байна, тийм үү, эрдэнэ минь? Тийм-шшш.

- Энийг одоо яах вэ? Минийхээр бол хойноос чаргууцалдаад байхгүйн тулд гар, хөлийг нь хүлээд хаячихмаар байна – гэж Сэм санал гаргав.

- Энэ чинь бидний хувьд үхэл, үххэл, - хэмээн Хорлум уйлагнаж: - Харгис хоббитууд! Эднар биднийг хүлээд, хатуу, хүйтэн хадан дээр өлсгөж алахаар хаях гэж байна, хорлум, хорлум!

Хоолой нь эхэр татан уйлж байгаа бололтой хоржигнов.

- Үгүй ээ, алах юм бол шууд алсан нь дээр – гэж Фродо хэлэв: - Гэхдээ энийг одоо алахад ичгэвтэр, муухай юм. Хөөрхий амьтан! Тэгээд ч бидэнд ямар ч хор хүргээгүй шүү дээ.

- Энэ ч үнэн - хэмээн Сэм мөрөө үрэнгээ бувтнаад - Чадаагүй, алах гэж завдсан. Боломж олонгуут ална. Нойрон дунд маань л багалзуурдчихна. Толгойд нь ганцхан ийм л бодол байгаа.

- Тийм л юм шиг байна, гэхдээ завдсаны төлөө алдаггүй биз дээ – гээд ямар нэг юм нэхэн санаж бодолхийлэв. Хорлум нам хэвтэж, уйлахаа ч болив. Сэм тэрнээс нүд салгалгүй муухай харж байлаа.

Харин Фродод тэртээ өнгөрсөн үеийн дуу хоолой тод сонсогдлоо:

- Бильбо тэр үхээрийг алаагүй нь ямар их харамсалтай вэ, тийм сайхан боломж байсаар байхад!

- Харамсал гэв үү? Чухамдаа харамсал л түүний гарыг тогтоосон юм.

Харамсал, нинжин сэтгэл хоёр. Гарцаагүй чухал шаардлагагүйгээр алж болохгүй.

- Хорлумыг өрөвдөх тэнэг хэрэг. Тэр үхэх хэргээ хийчихсэн.

- Хийх нь ч хийсэн л дээ, маргах юм байхгүй. Тэр ч гэсэн, тэрнээс өөр олон тийм этгээд ч гэсэн үхдлүүдийн легион. Тэгвэл амьдрах ёстой мөртөө үхчихсэн хүмүүсийг тоолох гээд үз. Хүн бүр байгуулсан гавьяандаа тохирч амьдрах ёстой гээд чи тэднийг сэхээн амьдруулж чадах уу? Чадахгүй. Тэгвэл хэнийг ч үхүүлэх гэж бүү яар. Яагаад гэвэл мэргэдийн мэргэд хүртэл бүгдийг урьдчилан харж чаддаггүй юм.

- Тийм ээ, чиний зөв – гэж тэр хэлээд, илдээ буулгаж: - Би үүнийг амьд үлдээхээс айж байна, гэвч алахгүй. Чиний зөв, үүнийг хаяж ч болохгүй, өрөвдөж ч болохгүй.

Сэм өөртэйгөө яриад байгаа ч юм шиг, өөр хэн нэгэнтэй яриад байгаа ч юм шиг эзэн рүүгээ гайхан харав. Хорлум толгойгоо өндийлгөлөө.

- Тийм ээ, бид хөөрхий амьтас, бид хөөрхий амьтас, эрдэнэ минь – хэмээн тэр гаслаад: - Бидэнд амьдрах хэцүү байна, хэцүү байна! Хоббитууд биднийг алахгүй, сайн хоббитууд.

- Алахгүй - гэж Фродо хэлээд: - Гэхдээ тавьж явуулахгүй. Чамд хэмжээлшгүй их хорсол, хорон санаа байгаа, Хорлум. Чи бидэнтэй хамт явах болно. Чамаас нүд салгахгүй. Нэгэнт чамайг өршөөсөн болохоор чи бидэнд туслах болно.

- Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав, бид зөвшөөрч байна зөвшшрччч – хэмээн Хорлум яаран хэлээд өндийж суув: - Сайн хоббитууд! Бид тэдэнтэй хамт явж, тэдэнд огт үзэгдэхгүй жимийг ямар ч харанхуй байсан хайж олоод өгнө, тийм үү, эрдэнэ минь? Хоббитууд энэ хатуу ширүүн, хад чулуун оронд хаашаа явж байгаа нь бидэнд сонин байна, машшш сонин байна!

Тэр хоббитууд руу зальтай, шунахай нүдээрээ цагаан хөмсгөн дороос цийлэгнүүлэн харав. Сэм түүн рүү хилэнтэйе харж, шүд зуун тэсч байв. Эзэнтэнд өөрийн бодол байгааг мэдрээд тэр оролцохгүй байсан нь дээр гэж бодлоо. Гэлээ ч гэсэн Фродогийн хариулт түүнийг бүр гайхшруулж орхив.

Фродо Хорлумын нүд рүү цоо ширтэхэд тэр нүдээ цавчлан гөлөлзөв. - Чи бидний хаашаа явж байгааг мэдэж байгаа, Смеагорл – гэж тэр аяархан бөгөөд хатуу хэлээд: - Мэдэхгүй ч гэсэн таамаглаж байгаа. Мэдээж, бид Мордор руу явж байгаа, тийшээ очих замыг чи мэднэ.

- Ахх! Ш-ш-ш-ш! – хэмээн хорлум саяны хэлсэн үг чихийг нь цоо хатгасан юм шиг алгаараа чихээ таглаад: - Таамаглаж байна аа, бид таамаглаж байна, тэгээд тэднийг тийшээ битгий яв гэж гуйж байна, тийм үү, эрдэнэ минь? Сайн хоббитууд тийшээ яах гэж очих юм бэ? Тэнд үнс нурам, тоос, хоолой хатаана, ус байхгүй, тгэнд энд тэндгүй нүх ухаастай, орхууд энд тэндгүй мянга мянгаараа шиншилж явдаг. Тийм газар руу ийм ухаантай, сайн хоббитууд явах хэрэггүй, хэрэггүй шүү-шшш.

- Тэгэхлээр чи тэнд байсан юм уу? Одоо хүсээгүй байхад ч гэсэн дахин тийш нь чангаагаад байгаа юм биз дээ?

- Тийм ээ, дахиад л, даххиад л- гэснээ: - Үгүй ээ! – хэмээн Хорлум бархирч: - Энэ бол санамсаргүй болсон явдал, үнэн биз дээ, эрдэнэ минь? Тийм ээ, бүр огт санамсаргүй. Дахиад л бид тийшээ явахыг хүсч байна, үгүй, үгүй!: - гэснээ түүний дуу хоолой танигдахын аргагүй өөрчлөгдөв. Тэр эхэр татан уйлж, хоолой нь хоржигнох бөгөөд хоббитуудаас огт өөр этгээдтэй ярьж байлаа:

- Намайг орхи, намайг явуул, хорлум! Их өвдөж байна. Хөөрхий миний сарвуунууд, хорлум! Би, биш ээ бид чам руу эргэж ирэхийг хүсэхгүй байна. Би тэрнийг олж чадахгүй. Би их ядарлаа. Би, бид тэрнийг олж чадахгүй, хорлум, хорлум, тэр хаана ч алга байна. Тэд намайг тандаж байна, унтах ч үгүй байна. Гномууд, хүмүүс, эльфүүд, гал бадарсан нүдтэй аймшигт эльфүүд. Би тэрнийг олж чадахгүй. Аххх! – гээд тэр хөл дээрээ босон харайж, ясан нударгаараа дорно зүг рүү занан: - Түүнийг хайхаа болилоо! Чамд олж өгөх гэж хайхгүй – гэснээ газарт хөсөр унаж: - Хорлум, хорлум! Бидэн рүү битгий хараад бай, яв! Явж унт!

- Чиний үгээр бол, Смеагорл, тэр явах ч үгүй, унтах ч үгүй. Гэвч чи үнэхээр түүнээс

хагацахыг хүсч байгаа юм бол надад тусал. Тэгэхийн тулд чи намайг түүний улсад хүргэж өг. Зөвхөн хаалганд нь л хүргэнэ, надтай хамт дотогш орох хэрэггүй.

Хорлум дахин өндийж суугаад, хагас буусан зовхиныхоо доороос Фродо руу харав:

- Тэр хаана байгаа нь мэдээж, тэр дандаа тэнд, ганцхан газарт л байдаг юм. Орхууд та нарыг хүргээд өгнө, тэд энэ зүүн эргээр бөөн бөөнөөрөө тэнэж яваа. Смеагорлыг битгий гуй. Хөөрхий, хөөрхий Смеагорл, тэр байхгүй, тэр үхчихсэн. Тэрний эрдэнийг булаагаад авчихсан, тэр баларсан.

- Олдож ч магадгүй шүү дээ, хамтдаа хайцгаая

- Үгүй үгүй, хэзээ ч олдохгүй! Эрдэнэ алга болсон

- Бос! - гэж Фродо тушаав.

Хорлум босч, хясааны хана налан зогсов.

- Шийд! Жимийг өдөр хайсан нь дээр үү, шөнө хайсан нь дээр

үү? Бид их ядарсан, гэвч чи шөнө явсан нь дээр гэвэл бид одоо явна.

- Муухай хурц гэрэл бидний нүдийг шардаг, одоо цагаан хоншоор тэнгэрт байгаа, одоо арай эрт байна. Удахгүй тэр уулын цаагуур орно. Жаахан амарч ав, сайн хоббитууд минь!

- Тэгвэл суу! Зугатах гэж санасны хэрэггүй шүү!

Хоббитууд түүний хоёр талд, хана налан сууж, хөлөө жийв. Тэгэх ч хэрэгцээ байсангүй, хоромхон зуурт ч зүүрмэглэж болохгүй гэдгийг хоёулаа сайн мэдэж байлаа. Сар удаанаар жаргаж, саарал хясаанууд харлаж эхэллээ. Тэнгэрт тодхон одод яралзав. Тэр гурвын хэн нь ч хөдөлсөнгүй. Хорлум эрүүгээ өвдгөн дээрээ тавиад, үлбэгэр дөрвөн мөчөө газраар тэрийлгэн суух бөгөөд нүд нь аниатай боловч бүх биеэ хөдлөхөд бэлэн хурааж байлаа. Тэр тохиромжтой мөч болохыг хүлээж буй нь илт.

Фродо, Сэм хоёр бие бие рүүгээ хараад, бага зэрэг бие тавиран толгойгоо гэдийж, унтах гэж буй мэт нүдээ анив. Төдөлгүй тэр хоёрын жигдхэн амьсгаа сонсогдож эхлэв. Хорлумын хуруунууд чичирч эхэллээ. Тэр толгойгоо үл мэдэг эргүүлэв. Хоёр цийлэн цэхэр нүд нь ээлжлэн нээгдлээ. Хоббитууд унтаж байгаа нь илт.

Хорлум гэнэт дэвхрэг юм уу, мэлхий шиг үсрэн харанхуйд алга болов. Фродо, Сэм хоёр ингэхийг нь л хүлээж байжээ. Сэм хоромхон зуурт түүн дээр харайн хүрч, тэврэн авахад Фродо хөлийг нь дэгээдэж унагав.

- Дахиад л чиний аргамж хэрэг болох нь дээ, Сэм.

Сэм аргамжаа гаргаж ирлээ.

- Аа, та хатуу, хүйтэн хад чулуун дундуур хаашаа ингэж их яардаг билээ? Миний эрдэнэ, эрхэм ноён Хорлум? Бидэнд сонин байна, бидэнд маш их сонин байна! Толгойгоороо андгайлъя, найз орхууд руугаа л биз дээ! Аа, чи муу өмхий, хуурамч шавьж! Чиний хүзүүнд энэ олсыг углаад чангахан татах юмсан.

Хорлум саяхан л яаж шарвалзаж, уйлж үглэж байгаагүй юм шиг нам хэвтэх бөгөөд зөвхөн Сэм рүү үзэн ядсан харцаар шөвөгдөнө.

- Энэнийг зүгээр л аргамжаатай авч явъя. Хөлийг нь хүлэх хэрэггүй, явж чадахгүй, ер нь гарыг нь ч хүлэх хэрэггүй, дөрвөн хөллөж явдгаас хойш. Шагайнаас нь уяад өөртэйгөө холбочих – гэж Фродо хэлэв. Тэр Сэм хэрхэн уяж байгааг харан зогсч байтал хорлум тэр хоёрыг мэл гайхуулав. Тэр гэнэт аймшигтай муухайгаар тасралтгүй хашгиран, чулуун дээгүүр өнхөрч, мушгиралдан, шүдээрээ аргамжийг таслах гэж шагайгаа хэмлэж гарав.

Фродо эцэст нь тэр худлаа авирлаагүй юм байна гэдгийг ойлгоод, аргамжийг дэндүү чанга уясан юм болов уу гэж бодоод шалгаж үзэв. Гэтэл чанга байтугай хэтэрхий сулхан уяжээ. Сэм аман дээрээ л айхтар чанга болохоос биш ажил дээрээ тийм биш ажээ.

- Юу болоод байгаа юм бэ?! Чи зугтах гээд байгаа учраас аргамжаатай явах хэрэгтэй. Хэн ч чамайг өвтгөөгүй байна – гэж Сэм зандрав.

- Үгүй ээ, бид их өвдөж байна, их өвдөж байна! Аргамж, хазаад байна, хөлдөөгөөд байна! Харгис хэрцгий, муухай хоббитууд! Тэгээд л бид зугтах гэсэн юм, тийм ээ эрдэнэ минь? Хоббитууд биднийг тарчлаан тамлана гэж бид таамаглаж байсан юм. Тэд хорон галт нүдтэй эльфүүдтэй хэлхэлдээд байсан юм. Тайлаад өгөөч, Тайлаад өгөөч! Бид их өвдөж байна!

- Үгүй ээ, тайлахгүй, - хэмээн Фродо толгой сэгсэрч: - Чи надад тангараглаж, би тэрэнд чинь үнэмших болж байна уу?

- Бид дуулгавартай байхаа тангараглана, тийм ээ, тийм-шшц, - Бид их өвдөж байна!

- Тангараглаж байна уу?

- Смеагорл тангараглаж байна – гэж Хорлум гэнэт тов тод дуугаар хэлээд Фродо руу хачин гялалзсан нүдээр харж: - Смеагорл эрдэнээрээ тангараглаж байна -гэв.

Фродо гэнэт нуруугаа эгцлэн зогсоход түүний хатуу үг болон дуу хоолой нь Сэмийг дахин гайхашруулав.

- Эрдэнээрээ гэнэ ээ? Яаж байгаа чинь энэ вэ! Ухаараач!

Нэг бөгж тэднийг захирна

Хар гинжинд тэднийг давтана.

Чамд юу заналхийлж байгааг чи ойлгож байна уу, Смеагорл? Чи өөрийн эрхгүй ингэж тангараглаж байна. Гэвч тангараг чинь чамайг барьж өгнө. Болгоомжил!

Хорлум агзасхийж, чихээ дарав.

- Эрдэнээрээ, Эрдэнээрээ! – гэж тэр давтлаа.

- Юу гэж тангараглаж байгаа юм бэ? – гэж Фродо асуув.

- Тэр дуулгавартай байна гэж тангараглаж байна – гээд Хорлум Фродогийн хөл рүү мөлхөн очиж, айсандаа бүх яс нь салах гэж байгаа юм шиг чичрэн байж, сөөнгө дуугаар:

- Смеагорл түүнийг хэзээ ч, хэзээ ч Түүнд өгөхгүй гэж тангараглаж байна. Хэзээ ч! Смеагорл түүнийг хадгалж, оршуулна. Зөвхөн түүнд эрдэнээрээ тангараглах боломж олго.

- Үгүй ээ! Ингэж болохгүй – гэж Фродо хэлээд түүн рүү ширүүн бөгөөд өрөвдөнгүй харлаа.

- Чи түүнийг харж, барьж үзэх нь ухаангүй тэнэг хэрэг гэж мэдэж байгаа ч гэсэн тэгэхийг улайран хүсч байна. Хүсч байгаа бол түүгээр биш, харин түүнд тангарагла, хаана байгааг нь чи мэдэж байгаа. Тэр чиний өмнө байна.

Фродо гэнэт суга өсч, хорлум бүр хатчих шиг Сэмд санагдав. Сонголтын нууц тэмдгийг саарал өмсгөл дотроо нуусан агуу сүүдэр, хүчирхэг эзэн, түүний хөл дор гасалж гийнасан нохойнцор байгаа юм шиг. Гэвч энэ хоёр садан төрлийн холбоотой болжээ. Тэр хоёр бие биеийгээ зүрхэн дотроо уншиж байлаа. Хорлум өвдөг дээрээ сууж, Фродогийн хөлийг тэврээд гөлөг шиг шарвалзаж байв.

- Зайл! Зайл! Тангаргаа хэл!

- Бид тангараглаж байна, тийм ээ, би тангараглаж байна! Эрдэнийн эзэнд үнэнчээр зүтгэхээ тангараглаж байна. Сайн эзэн, дуулгаварт Смеагорл, хорлум, хорлум.

Тэр гэнэт уйлж, дахиад л шагайгаа мэрлээ.

- Тайлчих, Сэм! - гэж Фродо тушаав.

Сэм тушаалыг тун ч дургүй биелүүллээ. Хорлум тэр даруй босон харайж, эзэн нь өршөөж, эрхлүүлсэн нохой шиг тойрон харайж гарав. Энэ мөчөөс эхлэн түүний араншин түр ч гэсэн өөрчлөгдлөө. Шуухитнаж, гийнаж, исгэрэхээ бараг больж, өөртөө болон эрдэнэдээ хандаж ярихаа болиод ярилцаж байгаа этгээдээ хандаж ярьдаг болов. Тэр мань хоёр хоббитын гэнэтийн хөдөлгөөн бүрт биеэ хураан чичирч, эльф цувнуудаас үхтлээ айн, ойртохоос дөлж байсан ч эелдэг, өрөвдмөөр долигонуур байлаа. Тэр ямар ч хошин юм ярихад инээдэндээ хахаж цацаж байгаа бололтой хяхтнан, Фродо өөрт нь эелдэг хандвал байдгаараа баярлан харайж дэвхэрч, Фродо зэмлэвэл нулимсандаа хахаж цацдаг болов. Сэм түүнтэй бараг үг солихгүй, юуханд нь ч итгэхгүй байлаа. Шинэ Хорлум, Хорлум-Смеагорл түүнд өмнөхөөсөө ч ой гутам зэвүүн байв.

- За яахав, Хорлум, эсвэл хэн ч гэж дуудах юм – гэж тэр хэлээд: - Явья! Сар орчихлоо, шөнө дуусах дөхөж байна. Замдаа гарья - гэлээ.

- Явцгаая, явцгаая, - гээд Хорлум босон харайж:

- Хурдан явцгаая! Хадан орноос намаг гаталж гарах ганцхан зам бий, хойшоо ч, урагшаа ч өөр зам байхгүй. Би тэрнийг аль эрт олсон юм. Орхууд түүгээр явдаггүй, тэд тэр замыг мэдэхгүй. Орхууд намгаас айдаг, тэд намгаас олон бээрийн цаагуур явдаг юм. Та нар энд ирсэн чинь сайн хэрэг. Смеагорлыг олсон чинь сайн, тийм шүү. Смеагорл та нарыг эндээс аваад гарнааа!

Тэр урагшаа түрүүлэн гүйж, эзнээ зугаалъя хэмээн дуудаж байгаа нохой шиг эргэж харав.

- Чи аядаарай, Хорлум! Битгий гүйгээд бай, би чамаас хол хоцрохгүй, аргамж бэлэн байна – Сэм хашгирав.

- Үгүй ээ үгүй, тэр зугтаахгүй! - гэж Хорлум хариулаад: - Смеагорл тангарагласан.

Тэд одтой шөнөөр замдаа гарлаа. Хорлум тэр хоёрыг буцааж хойт зүг рүү дагуулснаа удалгүй Дайсны хөндийн уулсыг ардаа орхин эргэж, бөөн бөөн чулуун дундуур хязгааргүй намгийн зах руу алхав. Тэд шөнийн харанхуйд хурдан бөгөөд чимээгүй уусан орлоо. Мордорын хаалганы өмнөх удам намагт орон зайд харанхуй нам гүм хаанчилж байлаа.

Бүлэг 12

Намаг дундуурх жим

Хорлум хүзүүгээ сунгаж, толгойгоо дүүжигнүүлэн хоёр хөлөөрөө ч, дөрвөн хөллөөд ч адилхан хурдан явдаг ажээ. Фродо, Сэм хоёр түүний араас арай ядан гүйцэж байлаа. Гэвч тэр зугтаах хүсэлгүй бололтой, мань хоёр хоббитыг хол хоцрохоор эргэж харан хүлээж байлаа. Тэд өмнө нь дайрч өнгөрсөн хонхортоо ирсэн боловч уулын бэлээс нэлээд хол байв.

- Аа, энэ байна - гэж Хорлум хашгираад: - Тэр доор жим байна, бид түүгээр зөндөө явж байгаад тээр тэндээс гарна – хэмээн зүүн өмнө зүг рүү, шөнийн цэнгэг агаарыг бузарлаж буй илжирхий, өмхий үнэрт намгийн тийш заав.

Хорлум хонхрын ирмэг дээгүүр дөрвөн хөллөн харайж байснаа тэр хоёрыг дуудлаа:

- Нааш ир! Үүгээр буухад амархан. Смеагорл үүгээр нэг удаа явж байсан, үүгээр явж, орхуудаас нуугдаж байсан.

Хоббитууд түүний араас даган доош буухад үнэхээр дөхөмтэй байв. Өргөнөөрөө арван хоёр фут орчим, гүнээрээ арван таван футээс хэтрэхгүй энэ хонхор Дайсны хөндийгөөс урсан ирж, өмхий намгийг тэжээдэг үй олон горхийн нэгнийх нь голдрил байжээ. Хорлум баруун тийш эргэж, дараа нь өмнө зүг рүү бага зэрэг хазайгаад, тэгшхэн чулуун ёроолоор шал палхийлгэн гүйлээ. Түүнд ус маш тааламжтай байгаа бололтой, тэрүүхэндээ баяртайгаар хи-хи-хи хөхөрч, тэр ч байтугай хамар дороо нэг дуурхуу юм үглэж явлаа:

Хөлийг минь хүйт мэрээд,

Ходоодыг минь өлсгөлөн мэрээд

Хоосон зовлогыг минь чулуунууд хазаад

Яс мэрье гэхээр

Ясан шүд минь хугараад

Яасан зовлонт хорвоо вэ?

Зөөлөн нойтон гол

Зүрхийг минь баярлуулж,

Хөлийг минь илж байна.

Хөгжөөнтэй инээж байна ...

- Ха-ха! Хэнд бид инээж байгаа билээ? – хэмээн тэр хоббитууд руу хялайн харангаа

гуншганаад: - Хэнд гэдгийг одоохон хэлээд өгье. Тэр тэгэхэд өөрөө таамаглаж байсан, гурвантаа хараал идсэн Торбинс.

Түүний нүд харанхуйд ёозгүй муухай гялсхийв. Энэ гялсхийлт Сэмд тун ч таалагдсангүй.

Амьтай мөртөө амьсгалдаггүй,

Чихгүй мөртөө сонсдог.

Үүрэн дотроо тэр

Үхсэн юм шиг хүйтэн.

Уугаад уугаад ханадаггүй,

Газар дээр үсэрч өнхөрдөг.

Гялалзаж гялтганадаг,

Гилгэр, гөлчгөр!

Инээж байгаад чамайг дуудъя:

Ирээрэй, амттай өөхтэй загас

Энэ дуу шиг юм Сэмийн санааг түгшүүлэв. Эзэн нь Хорлумыг газарчаар авахаар шийдэхэд л Сэм нэг юманд их санаа зовж байсан билээ. Тэр нь идэх юмны тухай бодол байсан юм. Эзний санаанд ийм бодол огт ороогүй нь мэдээж, харин Хорлумын санаанд орсон л байж таараа. Ер нь Хорлум хорвоо дээр ганцаараа тэнэж явахдаа яаж хоол олж иддэг байсан нь сонин. “Тун ч тааруухан хооллодог байж дээ. Өлсөхийн ихээр өлссөн нь илт байна. Хэрэв загас баригдахгүй бол хоббитын махнаас цээрлэхгүй л юм байна. Унтах л юм бол хоромхон зуурт хоёуланг маань эд бад хийчихнэ дээ. За, Сэм Скромби минь, чамд л хамаг найдвар байна шүү” – гэж Сэм бодлоо.

Тэд харанхуй, муруй тахир хонхроор зөндөөн удаан явж, ядарсан хоёр хоббитод энэ зам эцэс төгсгөлгүй юм шиг санагдаж байв. Хавцал зүүн тийшээ эргэж, арай өргөсөхөд гүн нь аажмаар багасав. Саарал утаа манарч байгаа нь үүр цайх дөхсөнийг илтгэнэ. Их л шаламгай гүйж байсан Хорлум гэнэт зогтусан тэнгэр өөд харав.

- Өдөр ойрхон байна – гэж тэр хэлээд үгийг нь сонсонгуутаа өдөр түүнийг барьж авах гэж байгаа юм шиг навтасхийв.

- Смеагорл энд нуугдана, тэгээд шар хоншоор намайг үзэхгүй.

- Бид хоёр нар харвал баярлах л байна, даанч дээшээ гарах чадал алга, өвдөг нугараад явж өгөхгүй нь – гэж Фродо хэлэв.

- Шар хоншоорт баярлах хэрэггүй, тэр биднийг зориуд дайснуудад барьж өгнө. Сайхан санаатай, ухаантай хоббитууд Смеагорлтой хамт нуугдана, тэгэхгүй бол эргэн тойронд орхууд, хорон санаат хүмүүс шиншилж байгаа, тэд их хол хардаг юм. Энд Смеагорлтой хамт нуугдацгаа, хоббитууд минь!

Босоо хүн эргэн тойрноо харж болохоор нэг хонхорт амрахаар саатав. Нэлээд алсхан нэгэн горхи шоржигнож, хөл доор хуурай, хатуу газар байна. Фродо, Сэм хоёр нэгэн том чулуу налан суув. Хорлум горхин дотор шал палхийлгэн нэг юм ухаад завгүй.

- Жаахан юм идэх хэрэгтэй, Смеагорл, чи өлсч байгаа биз дээ? Бид хоёрт идэх юм бага байна, гэхдээ хуваалцъя – гэж Фродо хэлэв. "Өлсөж" гэдэг үг сонсоод Хорлумын нүд жигтэйхэн ногоон туяа татуулан бүлтэлзэв. Тэр нөгөө л хуучин хорлум өнгөөрөө ярилаа:

- Бид бүр үхтлээ өлсчихлөө, эрдэнэ минь. Эд нарт ямар идэх юм байгаа юм бол? Шүүслэг загас юм болов уу?

Хурц шар шүднийх нь цаанаас урт нарийхан хэл гарч ирээд цусгүй уруулаа хомхойлон долоов.

- Үгүй ээ, бид хоёрт загас байхгүй, энэ л байна – гээд путлиб үзүүлж, энэ усыг ууж болдог юм бол ус ууна – гэлээ.

- Тийм шшүү, уссс сссэвэрхэн, байгаа дээр нь сайн ууж аваарай. Эдний аманд юу шаржигнаад байна аа, эрдэнэ минь? Энэ их амттай юу?

Фродо түүнд навчинд ороосон путлиб хэлтэлж өгтөл хорлум навчийг үнэрлээд, нүүр нь ой гутам муухай муруйж, нүд нь хорсол дүүрэн гялалзав.

- Смеагорл юу үнэртэж байгааг мэдэж байна! Энэ бол эльфүүдийн орны навч байна, кха! Ф-ф-ф, ямар муухай үнэртэй юм бэ! Тэр тэндхийн моднуудад авирч байсан, өмхий үнэр түүний гарт үлдсэн – гээд тэр навчийг шидэж, путлибыг амсч үзсэнээ нулимж орхиод, хахаж цацан :

- Аххх! Үгүй ээ, үүнийг идэж болохгүй, хөөрхий Смеагорл та хоёроос болж цацаж үхэх нь. Тоос, үнс хоёр. Үүнийг идэж болохгүй. Гэвч Смеагорл тэснэ. Сайн хоббитууд аа! Смеагорл андгайлсан. Тэр өлсөнө. Хоббитын хоол тэрний хоолой руу орохгүй, тэр өлсч үхнэ. Хөөрхий туранхай Смеагорл!

- Харамсалтай л байна, гэвч чамд өөр өгчих юм алга даа. Энэ хоол чамд их хэрэг болно гэж бодсон юм. Гэвч одоохондоо оролдох ч хэрэггүй юм шиг байна – гэж Фродо хэлэв.

Хоббитууд дуугүйхэн путлибаа шаржигнуулж суулаа. Путлиб өмнөхөөсөө сайхан амттай болсныг Сэм анзаарав. Хорлумд энэ хүнс ямар гайхамшигтайг түүнд сануулсан боловч хооллох дурыг нь унтрааж орхив. Тэр хоолны ширээний дэргэд байгаа нохой шиг хэрчим бүрийг нүдээрээ дагуулан харж байлаа. Тэр хоёр бингээажилчихаад амрахаар хэвтэхэд Хорлум өөрөөс нь амттанаа нуугаагүйг ойлгож, хэдэн алхам холдон суугаад өөрийгөө өрөвдөн гасалж гонгинов.

- Эзэн минь! - гэж Сэм нэлээд чангаар шивнэв: Хорлум сонсч байгаа эсэх нь түүнд огт падгүй байв: - Яалаа ч гэсэн унтахгүй байх аргагүй, гэхдээ хоёулаа зэрэг унтаж яасан ч болохгүй. Тэр хорт могойг хараач, бид хоёрыг ямар муухай өлөн нүдээр хялайж байгааг нь. Тэрний ”андгай тангараг” ч яамай байна аа! Хорлум ч гэнэ үү, Смеахорлум ч гэнэ үү, нэг л чөтгөр. Бөгтөрийн нурууг булш засна, харин энэ одоохондоо амьд байна. Та унтаж бай, эзэн минь, би өөрөө яагаад ч тэсч чадахгүй болохоороо таныг сэрээе. Ээлжээр унтахгүй бол...

- Юу үнэн, тэр үнэн Сэм минь – гэж Фродо нуулгүй хэлээд: - Тэр үнэхээр өөрчлөгдсөн, гэхдээ хэр их гэдэг нь одоогоор мэдэгдэхгүй байна. Гэхдээ миний бодлоор бол өнөөдөр тэрнээс айх юм байхгүй, яахав, сэрэмжтэй байя. Хоёр цаг орчим болоод намайг сэрээгээрэй.

Фродо маш их ядарсан тул ингэж хэлэнгүүтээ нам унтав. Хорлум ч нохой шиг цагариглан хэвтээд юу ч болоогүй аятай унтаад өгөв. Гэвч зуулттай шүднийхээ завсраар сэжигтэй исгэрч байсан ч үхсэн юм шиг хөдөлгөөнгүй байлаа. Сэм хэсэг харж, чагнаж байснаа хариугүй унтах шахаж, босч Хорлум руу очоод өлмийгөөрөө зөөлхөн өшиглөв. Хорлумын атгаастай алга тэнийж, хуруу нь салганахаас өөр яасан ч үгүй. Сэм чих рүү нь тонгойж “амттайхан загас” гэж хэлэхэд Хорлум урьдын адил исгэрэн унтсаар байлаа.

Сэм шилэн хүзүүгээ маажив.

- Үнэхээр унтаж байгаа ч юм билүү, би Хорлум шиг юм байсан бол нэг хорлумыг нь цөөлөх байлаа – хэмээн амандаа бувтнав. Тэрбээр санаа алдаад, илд энэ байна, аргамж ч энэ байж л байна гэсэн аятайхан бодлоо хөөгөөд, эзнийхээ дэргэд ирж суув.

Тэр нүдээ нээгээд харахад тэнгэр унтахад байснаасаа хамаагүй бүрхэг болсон байв. Сэм босон харайгаад ийм сэргэлэн, их өлссөн байгаа юм чинь бүтэн өдөржингөө, лав есөн цаг унтсан байна гэж бодлоо. Фродо зөвхөн баруун тал руугаа эргээд амттайхан нойрондоо умбасан хэвээр. Хорлум бараа сураггүй болжээ.

Эцэг Жихар нь эцгийн үүргээ гүйцэтгэхдээ хүүгээ шагнасан олон тааламжгүй нэр хочийг Сэм санав. Жихарт тиймэрхүү үгсийн сан бэлэн байдаг байлаа. Эзнийх нь зөв байжээ. Айхгүй амьтнаас айсан байна. Ямар ч гэсэн хоёулаа бүрэн бүтэн, амьд мэнд байна.

- Аа муу тэнэмэл чамайг! – гэж илүү сэжиглэсэндээ өөрийгөө буруутган хэлээд:

- Ядаж тэр хаана салгалж явааг мэдэх юмсан – гэхэд:

- Ойрхон байна, ойрхон байна! – гэсэн дуу дээр нь гарахад тийш харвал үдшийн тэнгэрийн бараан дэвсгэр дээр Хорлумын том толгой, дэлдэн чих харагдав.

- Хөөе, чи тэнд юугаа хийгээд байгаа юм бэ? – хэмээн Сэм хоромхон зуурт урьдхаасаа ч сэрэмжтэй болон асуув.

- Смеагорл өлсгөлөн байна. Тэр одоохон эргэж ирнэ – гэж Хорлум хариулав.

- Одоохон хүрээд ир, дуулж байна уу чи! – гэж Сэм зандарлаа. Гэвч тэр ор сураггүй болжээ.

Хашгирах дуунаар сэрсэн Фродо сэргэж, нүдээ арчин суув.

- Юу болоо! Хэдэн цаг болж байна?

- Хараахан мэдээгүй л байна. Нар жаргаж байх шиг байна. Нөгөөдөх чинь зугтаачихлаа. Өлсөөд байна гэнэ ээ.

- За яахав, яахав! Эргээд ирнэ ээ, айх юмгүй. Андгай тангараг нь мартагдаагүй байна, тэр эрдэнэсээсээ хаашаа ч холдохгүй.

Фродо тэр хоёр бүтэн өдөржин хөл гар нь чөлөөтэй, өлсгөлөн Хорлумын дэргэд санаа амар нам унтсанаа мэдээд бүхний учрыг олов.

- Жихарыг хий дэмий битгий сана, чи дөнгөн данган амьд байсан, муу юм юу ч болсонгүй, хоёулаа сайхан амарч авлаа. Өмнө маань хамгийн хүнд бэрх зам хүлээж байгаа шүү дээ. Түүнээс бэрх юм гэж байхгүй.

- Хүнс л хэцүү болох нь дээ. Бид хоёрт одоо хичнээн нөөц хэрэгтэй болох бол? Ажлаа хийчихээд дараа нь яах вэ? Энэ замын хүнс бид хоёрыг хөл дээр маань тогтоож байна. Гомдох юм алга. Эльф тогооч нарт гүнээ мэхийн ёслоё, гэвч ходоод хонгиноод л байна. Идэх тусам л нөөц маань багасаад байна. Бүсээ чангалаад, шүдээ зуугаад байвал гурван долоо хоногт хүрэлцэж магадгүй. Тэгэхгүй бол бид хоёр арай их идээд байна.

- Бид хоёрт хичнээн хугацаа хэрэгтэйг би мэдэхгүй байна л даа. Уул хадаар удаан л бэдэрлээ. Эрхэм хүндэт Сэммиум Скромби, найзын найз минь, бид хоёр чиний хэлснээр ажлаа хийчихээд дараа нь яах тухай бодохын ч хэрэггүй гэдгийг л чамд хэлье. Тэр тухайд найдсаны хэрэггүй, бид хоёр хийж чадаж л байвал дараа нь яах нь хамаагүй! Бүхнийг захирагч бөгж галд унаад, бид хоёр хажууд нь байж байна гэж төсөөлөөд үз дээ! Бид хоёрт талх хэрэг болох уу, өөрөө бодоод үз. Тэр цагт бид хоёрт талх хэрэггүй болно. Яаж ийгээд Галт ууланд яваад хүрчихвэл болох нь тэр. Харин хүрч чадах нь уу, үгүй юу?

Сэм дуугүй толгой дохиод эзнийхээ гараас барьж, толгой дээрээс нь бөхийн нулимсаа дуслуулаад, хамраа ханцуйгаараа арчаад буруу харав. Дараа нь босч, нааш цааш холхин :

- Энэ золигийн амьтан хаашаа алга болчихов – хэмээн үглэж байлаа.

Хорлум удаан хүлээлгэсэнгүй, хаанаас ч юм чив чимээгүй гэв гэнэт гараад ирэв. Гар, нүүр нь хар шавраар будагджээ. Тэр ямар нэг юм зажилж, шүлсээ савируулж байв. Юу зажлаад байгааг нь сонирхсонгүй. “Өт хорхой ч юм уу, юу юм, нэг тиймэрхүү л юм байж таарна, түй! Мөн ч дүүрсэн амьтан юм даа!” – гэж Сэм бодов.

Хорлум ч дуугарсангүй, горхиноос ханатлаа ууж, гар нүүрээ угаав. Тэгээд уруулаа долоосоор хүрч ирлээ.

- Өт л олж идлээ. Та хоёр амраа биз дээ? Явцгаах уу? Сайн хоббитууд бөх унтсан шүү. Одоо Смеагорлд итгэж байна уу? Тэгвэл сайн байна, маш их сайн байна.

Тэгээд л аян замаа хөөцгөөв. Хонхор улам налуу хавтгай эрэгтэй болж, чулуурхаг ёроол нь шаварлаг болж, горхи улам уртсан шоржигноно. Шөнө дунд өнгөрсөн боловч од, сар хар угаан үүлэнд халхлагдаж байлаа.

Зэврүүн хүйтэн үүрээр мань гурав хөвдөрхөг дов сондуул дамжин харайж, горхи зэвтэй юм шиг өнгөтэй нуурт цутгалаа. Агаарт үс сөрвөлзүүлэх өчүүхэн салхи байхгүй бүгчим байхад хуурай зэгс исгэрэн шивнэлдэж байх нь сонин.

Тэдний өмнөөс эцэс төгсгөлгүй дов сондуул үүрийн бүдэгхэн гэрэлд үргэлжилжээ. Харанхуйлан харагдах хонхоруудын дээгүүр хүнд уур нэвсийн зулагджээ. Тэндээс амьсгаа давчдам өмхий үнэртэнэ. Тэртээ өмнө зүгт Мордорын хадан хясаанууд манант тэнгисийн дээгүүрх аадрын хар үүл мэт ханарна.

Хоёр хоббит Хорлумын араас сохроор дагахаас өөр аргагүй. Ар талд нь хоёрхон алхмын цаана өмхий намагт юу нуугдаж байгааг мэдэхгүй. Хэрэв энэ газрыг бага зэрэг мэддэг байсан бол жаахан саатаж байгаад, арай арагш эргэж, зүүн зүгийг барин Мордорын хаалганы дэргэдэх эртний их тулалдааны талбар Дагорладын нүцгэн тал руу нууц зөргөөр явах хэрэгтэй байлаа. Гэхдээ тэнд хүрнэ гэсэн найдвар бараг л байхгүй. Хатуу хадан талбайд нуугдах газар байхгүй, орхууд болон Сауроны бусад цэргүүд өдөр шөнөгүй ийш тийш холхиж байгаа. Лориэний цув ч тэр хоёрыг аврах боломжгүй.

- Бид тийшээ яаж явах юм бэ, Смеагорл? Заавал тэр өмхий намаг руу орох хэрэг байгаа юм уу? – гэж Фродо асуув.

- Заавал орох хэрэг байхгүй, Хоббитууд Хар ууланд хурдан хүрч Түүний өмнө зогсч болно. Буцаж жаахан яваад, хойшоо эргээд, дараа нь зүүн тийш эргэвэл хатуу, хүйтэн зам дээр гарна, тэгээд л Түүн дээр яваад хүрчихнэ, тийм шүү. Тэр тийшээ байнга харж байдаг юм, Смеагорлыг тэнд л тэр харсан юм, их дээр үед дээ – гээд Хорлум дагжин чичирч: - Гэвч Смеагорл бас тэр цагаас хойш бүгдийг хардаг болсон, нүднээс гадна хамар, хөл нь ч хэрэг болсон. Арай бэрх, арай тойруу зам, гэвч түүний нүдэнд харагдахгүй явъя гэвэл хамгийн тохиромжтой зам. Смеагорлыг дагаад явцгаа! Смеагорл та хоёрыг энэ сайхан өтгөн мананд намаг дундуур дагуулаад явна. Смеагорлыг дагаад л яваад бай, тэгвэл тэр та хоёрыг тийм ч хурдан базаад авчихгүй байх.

Бүрхэг, салхигүй өглөө болж, намгийн уур царцсан юм шиг хөдөлгөөнгүй, газартай нийлсэн үүл тэнгэрийг бүрэн халхалж байлаа. Хорлум нар үзэгдэхгүй байгаад маш их баярлаж, мань хоёрыг яаруулна. Түр зуур амсхийгээд замаа үргэлжлүүлж, ганцхан алхаад л манан дунд живэх мэт далд оров. Ард нь Дайсны хөндий, урд талд нь Мордорын нуруу харагдах бараагүй болов. Хорлум түрүүлж, араас нь Сэм, сүүлд нь Фродо цувран явж байв..

Фродо хамгийн их ядарч, яаж ч аажуухан алхлаа гэсэн ямагт хоцорч явав. Намаг нь зөгийн үүр мэт. Цонхнууд, нугачаа, цөөрөм, исэнгэ горхинууд байлаа. Үзэгдэхтэй үгүйтэй нарийхан жимийг зөвхөн дадамгай хөлөөр тэмтэрч, гарамгай хурц нүдээр л харж болохоор байв. Энэ талаар Хорлум дэндүү гарамгай боловч хамаг байдаг ур дадлаа дайчилж явлаа. Урт нарийхан хүзүүн дээрээ дэнжгэнэсэн том толгой нь ийш тийшээ эргэлдэн, хамраа сартагнуулан үнэрлэж, амандаа ямар нэг юм бувгнана. Заримдаа гараа өргөж, - Зогс, цаашаа нэг ч бүү алх

гэсэн дохио өгөөд, өөрөө дөрвөн хөллөн мөлхөж, алга, ул хоёроороо намгийг асар болгоомжтой хүрэлцэн мэдэрч, чихээ наан чагнаж байв.

Ингэж явах дэндүү залхуутай, дэндүү ядаргаатай байлаа. Эндхийн өвөл үхэнг царцуу өнгөтэй, чөмөг царцам хүйтэн ажээ. Өвс ногоо үзэгдэх нь байтугай өчүүхэн ч шинж тэмдэггүй, зөвхөн хөөсөрхөг, хөхөнгөр замаг шиг юм л тосон хар мандал дээр тунарна. Үндсэндээ хүртэл ялзарсан цөөхөн зэгс манан дунд эргэж ирэхгүй зуны дурсамж болж, хий үзэгдэл мэт сэрийн сүүмэлзэнэ.

Жаахан гэгээ орж, манан дээш өндийн сийрэгжив. Өндөр тэнгэрт алтан нар хөөрсөн боловч өтгөн мананг нэвт гэрэлтэж үл чадан, бүдэгхэн цагаан толбо болж харагдав. Тэглээ гээд дулаахан болсонгүй, намгийн үхэнгэ орчин өчүүхэн ч сэргэсэнгүй, Хорлум агзагнан чичирч, аяархан хуухирч, шуухитнаж байснаа эцэст нь цаашаа явж болохгүй гэлээ. Тэр гурав анч ноходод хөөгдсөн араатан шиг нэгэн хонхрын ирмэг дээр атиралдан суув. Эргэн тойронд анир чимээгүй, зөвхөн хатаж, хугарсан зэгс л дуулдах төдий сэржигнэнэ.

- Ядаж ганц шувуу үзэгддэггүй юм байх даа! - гэж Сэм гунигтай хэлэв.

- Байхгүй, энд шувуу байдаггүй юм. Амттайхан шувуунууд – гээд Хорлум уруулаа долоож, могойнууд, намгийн өтнүүд, мөлхдөг, хөвдөг, ямар ч амтгүй юмнууд байдаг юм. Харин шувуу байхгүй – гээд санаа алдав.

Сэм түүн рүү зэвүүрхэн хялайлаа.

Тэр хоёр Хорлумтай хамт гурав хоног аялжээ. Гэгээн гэрэлт бусад хязгаарт үдшийн сүүдэр бууж байхад тэр гурав дахиад л замаа хөөв. Хорлум дэндүү болгоомжилж, нэг л итгэлгүй явсан учир хааяа түр сууж амарна. Тэгсээр үхмэл намгийн хамгийн гүнд тулж ирэхэд харанхуй болов. Хоббитууд Хорлумын хөдөлгөөн бүхнийг даган байдгаараа бөхийсөөр арай ядан газар хороож байв. Намаг улам усархаг болж, хөл доор арай хатуу газар тааралдахаа болив. Хоббитууд бие жижиг, жин хөнгөн байгаагүй бол тэндээс гарах боломжгүй байлаа.

Удалгүй тас харанхуй болж, амьсгалахад ч хэцүү болов. Гэнэт эргэн тойронд гал гялалзахад Сэм солиорч байгаа юм болов уу гэж бодоод нүдээ арчин харав. Хоёр хоббит гайхахын ихээр гайхаж, эцэст нь Сэм тэссэнгүй:

- Энэ юу болоод байна аа, Хорлум? Юун галнууд вэ? Эргэн тойрон гал, хаанаас гараад ирэв? – гэж шивэгнэн асуув.

Хорлум толгойгоо өндийлгөв. Тэр усан намгийг тэмтэрч, үнэрлэн мөлхөж байснаа:

- Тийм байна, биднийг бүсэлсэн байна. Биднийг үхдлүүд рүү дуудаж байгаа юм. Чамд тэд ямар хамаа байна? Тэдэн рүү битгий хар! Тэндээ л бүжиглэж байг! Эзэн хаа байна?

Сэм эргэж харав. Фродо дахин хоцорч, бүр бараа нь ч алга байв. Сэм эзнээ аяархан дуудан

эргэж алхам тутамдаа тэмтрэн хэд алхав. Тэгээд цайвар галууд руу харан зогсч байгаа Фродотой мөргөлдлөө.

- Явцгаая, эзэн минь! Тэдэн рүү битгий хар! Хорлум тэгж хэлсэн. Хурдхан шиг энэ үхмэл газраас холдоё, яаж ийгээд гарья!

- Зүйтэй – хэмээн Фродо унтаад цочин сэрсэн мэт хэлж - Явцгаая, битгий саат! – гэв.

Сэм яаран эргээд хэд алхтал ямар нэг юманд тээглэн унаж, намагт живэх шахав. Нэг л хачин зэвүүн шуухитнаа сонсдож, өмхий самхай үнэртэн, нөгөө галууд бүжиглэн ойртов. Нүдний нь өмнөх хар намаг гэнэт харанхуй цонх болж, тэр цонхоор харангуутаа хамаг чадлаа шавхан гараа намгаас суга татан ухарлаа.

- Энд булш байна! Өчнөөн олон үхдэл байна, бүгдээрээ бидэн рүү харж байна! – гэж тэр хашгирахад:

- Үхдлүүдийн намаг гэж нэрлэдэг юм шүү дээ, гал харагдаж байхад намаг руу харж болохгүй! – хэмээн Хорлум хорон муухай хөхрөв.

- Тэд хэн юм бол? Хаанаас гараад ирсэн юм бол? – гэж Сэм Фродогоос асуув.

- Хэн гэдгийг нь мэдэхгүй юм, гэхдээ би ч бас тэднийг харсан. Тэд хар нүхэнд хэвтээд, үхсэн нүдээр харж байна. Хачин муухай, аймшигтай нүүрнүүд байсан, харин дэргэд нь гашуудалтай мөртөө агуу, бардам, гоо сайхан царайнууд харагдсан, тэдний мөнгөлөг үсийг усны ургамал ороосон байсан. Бүгдээрээ үхсэн, илжирсэн байсан, тэднээс булшны гэрэл гарч байсан – гэж Фродо нойрмог дуугаар хэлээд алгаараа нүүрээ арчиж - Тэд хэн юм, хаанаас гараад ирсэн юм би мэдэхгүй, би эльфүүд, хүмүүс, бас орхуудыг харсан байх.

- Тэр үнэн, бүгд үхсэн, илжирсэн. Эльфүүд, хүмүүс, орхууд. Тэгээд үхдлүүдийн намаг гэж нэрлэсэн байхгүй юу. Энд их байлдаан болсон. Энэ тухай Смеагорлд эмээ нь ярьсан юм. Тэгэхэд эрдэнэ олдоогүй байсан. Урт илдтэй өндөр хүмүүс, аймшигт эльфүүд орхуудтай байлдсан. Тэд Хар хаалганы дэргэдэх талд олон хоног, олон сар байлдсан. Орхууд зогсоо зайгүй орилолдоод байсан. Дараа нь намаг мөлхөж ирээд тэднийг залгисан.

- Гэвч хэдэн мянган жилийн өмнө тийм юм болсныг би мэдэхгүй. Үхдлүүд тэнд байх ёсгүй! Илбэ юм уу, элдэв хар шидийн үйл юм уу?

- Мэдэхгүй ээ, Смеагорл түүнийг мэдэхгүй, мэдэх гэж оролдох ч хэрэггүй. Бид нэг удаа оролдоод үзсэн, тийм ээ миний эрдэнэ минь? Тэгээд мэдэж чадаагүй. Тэдний нүд нь хардаг, харин шүд байхгүй, тийм ээ, миний эрдэнэ минь! Тэд үхсэн, тэд байхгүй.

Сэм тэрнийг зэвүүрхэн харж байснаа яагаад Смеагорл тэднийг мэдэх гэж оролдсоныг тааж орхив.

- За за, тэр үхдлүүд надад падгүй! Бид эндээс яаж хурдхан шиг зайлах вэ?

- Тийм ээ, хурдан л бол сайн, хуррдан мөртөө боллгоомжтой, тэгэхгүй бол хоёр хоббит

минь үхдлүүдтэй нийлээд гэрэл гаргаж магадгүй шүү. Смеагорлын мөрөн дээр гишгээд л яваад бай! Гал руу битгий хар!

Тэр баруун тийш эргэн мөлхөхөд мань хоёр түүнийг алдчихгүйг хичээн араас нь дагав. Аргагүйн эрхэнд дөрвөн хөллөсөн Сэм “дахиад жаахан мөлхвөл нэг биш, бүхэл бүтэн гурван Хорлумын эрдэнэ гараад ирэх вий!” – гэж бодлоо.

Тэгсгээд жим олдож, тэр гурав мөлхөх газар нь мөлхөж, нялцгай сондуул дамжин харайж, халтирч, өмхий хар шаварт унан тусаар цааш ахилаа. Хөлөөсөө толгойгоо хүртэл нэл шавар болж, булшнаас гарч ирсэн юм шиг өмхий ханхлуулан явсаар шөнө дунд болоход арай хатуу хөрсөн дээр гишгэв. Хорлум шуухтнан өөрөө өөртэйгөө шивнэн ярьж байгааг нь харвал сэтгэл хангалуун байгаа бололтой. Гарамгай мэдрэмж, онцгой үнэрч хамар, ер бусын сайн ой той нь түүнийг хэрэгтэй газарт нь хүргэв бололтой. Цаашаа хаагуур яаж явахаа тэр сайн мэдэж байлаа.

- За ингээд яваад байна даа, ухаантай хоббитуудхан минь, зоригтой хоббитууд минь! Бүр ядарчихаж, бид ч гэсэн эрдэнэ минь бас ядарчихлаа. Гэвч эзнийг үхдлүүдийн галаас хурдан холдуулах хэрэгтэй, тийм ээ холдуулах хэрэгтэй – гэж Хорлум хэлээд зэгсэн дундуур үсрэх шахан гүйхэд мань хоббитууд араас нь арайхийн гүйцэж явлаа. Тэр гэнэт зогтусан дөрвөн хөллөөд хамраа сартагнуулан үнэрлэж, тун ч сэтгэл дундуур, түгшүүртэйхэн шуухитнав.

- Юу болоов? – гэж Хорлум цээрлэн тургиж байхыг ажсан Сэм гүйж ирэнгээ асуув:

- Яагаад хамраа сарталзуулаад байгаа юм бэ? Би хамраа чимхээд байхад хүртэл энэ өмхийгөөс нүд бүлтэрчих гээд байна. Чи ч шал өмхий, эзэн ч шал өмхий, эргэн тойрон өмхий.

- Тийм ээ тийм, Сэм ч бас өмхий байна! Хөөрхий Смеагорл үнэрлэхэд хэцүү байна, гэхдээ дуулгавартай Смеагорл тэвчинэ ээ, сайн эзэндээ тусална. үнэртэж л байг, гэвч энэ агаар нэг л эвгүй болчихлоо, Смеагорлд энэ таалагдахгүй байна.

Тэр цааш гэлдэрснээ төдөлгүй зогсч, байн байн хүзүүгээ түгшүүртэйгээр гүлдийлгэн зүүн өмнө зүг рүү чих тавин чагнаж байв. Чухам юунд ингэж сэтгэл түгшээд байгааг нь хоббитууд эхлээд ойлгосонгүй, гэвч гэнэт гурвуулаа палхийтэл цочин сандрав. Фродо, Сэм хоёрт алсаас үргэлжилсэн урт бөгөөд жигтэйхэн хорсолд заналтай улих чимээ сонсогдов. Тэр улиан хэрхэн агаар чичрүүлж, ясанд хүртэл хүйт даалгаж байгааг тэр хоёр зэрэг мэдэрлээ. Дараа нь шуугин ирэх салхины чимээ сонсогдоод, нөгөөх галууд чичигнэн сүүмэлзсэнээ унтарлаа.

Хорлум огт хөдөлсөнгүй. Тэр чичрэн дагжиж, амандаа нэг юм үглэн байна. Салхи улин исгэрч, мананг зад татахад тэнгэрт уранхай үүл харагдаж, үүлэн завсраар сар харагдав. Хоёр хоббит хоромхон зуурт баярлахад Хорлум газарт наалдан Цагаан хоншоорт сарыг зүхэж гарав. Фродо, Сэм хоёр тэнгэр өөд харж, цэвэр агаараар цээж дүүрэн амьсгалахдаа хараалт хар уулнаас наашилж яваа асар том аймшгийн далавчит шавьжийг үзэв. Үхэл тээсэн өгүүлшгүй муухай орилооноороо чих дөжрүүлэн тэр мангас тэнгэрийн салхинаас түрүүлж баруун зүгт одов.

Мань гурав хадуурын ирэнд тасдуулсан өвс мэт унан, хүйтэн газарт атиралдав. Аймшигт мангас тэр дорхноо эргэж, тэр гурвын дээгүүр өмхий уурыг далавчаараа шүүрдэн өнгөрөв. Тэгээд Сауроны уур хилэнд дуудагдан Мордор руу буцаж одоход түүний араас даган уулгалсан салхи Үхдлүүдийн намгийн манангийн үлдэгдлийг оргүй болтол сарниав. Тэр гурвын урд талд нүд хүрэх газарт сүүмгэр уулын бэл дэх нүцгэн цөл сарны гэрэлд цэлийж байлаа. Фродо, Сэм хоёр босч, хар дарж зүүдлээд сэрсэн хүүхэд адил нүдээ арчин харав. Харин Хорлум газарт наалдсан хэвээрээ. Хоббитууд түүнийг яаж ч өшиглөж, сэгсчээд босгож чадсангүй, өргөн алгаараа чихээ таглаад, тохойгоо газарт шаасан чигээрээ хөдлөхгүй хэвтэнэ.

- Хий үзэгдлүүд! Далавчит хий үзэгдлүүд! Эрдэнийн минь зарц нар! Тэд бүгдийг хардаг, бүгдийг. Тэднээс нуугдах аргагүй. Хараал идсэн Цагаан хоншоор! Тэд түүнд бүгдийг ярина, тэгээд тэр биднийг харна, бүгдийг мэднэ, ээ чааваас, хорлум, хорлум, хорлум!

Сар Тол-Брандирын цаагуур орсон хойно л тэд замаа хөөв. Тэгмэгц Хорлум дахиад л өөрчлөгдөж байгааг Сэм анзаарав. Тэр аль байдгаараа долигنون нялганаж байвч, нүднийх нь харц нэг л сэжигтэй, ялангуяа Фродо руу харахаараа бүр ч хачин болж, яриа нь хуучин хорлумынх шиг болов. Хамгийн түгшүүртэй нь Фродо бүр туйлдаж гүйцэв. Тэр үг хэлэхгүй боловч даагдашгүй хүнд ачаа үүрсэн мэт бөхийн арай ядан гэлдэрч байлаа.

Түүний хажуугаар Мордорын хаалганд ойртох тусам бөгж хүзүүг нь улам хүндээр чангааж, газарт наах гээд байгаа юм шиг байлаа. Түүнийг нөгөө аймшигт нүд тарчлааж байв. Түүнээс болоод л бөгж Фродог газар руу чангаагаад байлаа. Газар, тэнгэр хоёрт юунд ч үл саатах тэр агуу хүчирхэг дайсан одоохон намайг олоод авна, түүнээс нуугдах нүх сүв байхгүй гэдгийг Фродо мэдэрч байлаа. Үхэл тээгч тэр цацраг хаанаас төөнөж байгааг ч Фродо мэдэж байв. Тэр цацраг нүүрийг нь төөнөөд байгаа учраас тийнхүү бөхийж явлаа.

Харин Хорлумд хамаагүй амар байх шиг. Гэвч түүний хатсан зүрхэнд ямар хүсэл байгааг, түүнийг аймшигт нүд зүвоож байна уу, гар сунгахад л бариад авах бөгжийг гартаа оруулах галзуу шунал уу, хүйтэн ган илдийн ирнээс айж өгсөн андгай юу гэдгийг хоёр хоббит мэдэхгүй байлаа. Энэ тухай Фродо огт бодсонгүй, харин Сэм өөрийнхөө айдсыг ч бараг үл анзааран эзнийхээ тухай бодож байлаа. Тэр одоо эзнийхээ араас алхаж, түүнийг нэг ч хором нүднээсээ үл салган, бүдрэхэд нь сугадан авч, эв хавгүй хошин үгээрээ сэтгэлийг нь сэргээхийг хичээж явлаа.

Үүр цайхад хоббитууд дүнсгэр бараан уулсад ямар их ойртсоноо хараад гайхав. Өглөөний хүйтэн, цэлмэг гэгээнд Мордорын хадан уулс нүсэр сүрлэг цамхагуудаараа эргэн тойрныг хичээнгүйлэн харах мэт. Намаг дуусч, хатаж хагарсан шавар хөрс, хааяа нэг хатангир бут үргэлжилжээ. Төмөр мэт саарал өнгөт өдөр дуусч, харанхуй болтол тэд асар том хадны хөмсөг дор далавчит мангас, нэвт шувг харагч аймшигт нүднээс өт хорхой шиг нуугдан суулаа. Тэд үхэнг өмхий намаг дундуур гурван өдөр, хоёр шөнө явснаа айдсаас болоод мартаж орхижээ. Эндхийн агаар нэг л хачин хатуу, хоолой хорсгосон утаа шиг байв.

Тав дахь өглөө нь тэд дахин зогсож, өмнөх замаа харлаа. Тэдний өмнө аварга том цохионууд саарал манан дунд сүглийж, тэдгээрийн орой нь утаан үүлэнд далдарч, бэл нь нүсэр бэхлэлтүүдээр хүрээлэгдсэн бөгөөд хамгийн ойрын хадан цохио хүртэл арван хоёр бээр хүрэхтэй үгүйтэй зай үлджээ. Фродо эргэн тойрноо харахад айдас төрөв. Үхдлүүдийн намаг,

хоосон цөл хичнээн бөөлжис цутгам муухай байсан ч одоо өмнө нь харагдаж байгаа орчин зуу дахин зэвүүн муухай байлаа. Үхдлүүдийн намагт хүртэл хавар болсныг илтгэх ногоон хальсанцар байсан бол энд хавар, зуны аль нь ч болох боломжгүй ажээ. Энд амьдын шинжтэй юу ч байхгүй, ядаж хүүрийн чандруу ч байхгүй аж. Зөвхөн цагаан саарал шавар, үнсэнд дарагдсан нүхнүүд л онгойж харлана. Шатсан шороо, буталсан хад чулуун овоонууд эцэс төгсгөлгүй үргэлжилж, үхдэлгүй булш мэт харагдах энэ газарт өдрийн гэрэл ч тусах дургүй байх шиг санагдав.

Энэ бол жинхэнэ Мордорын цөл, тоолшгүй олон боолуудын хүнд хүчир хөдөлмөрийн ул мөр байлаа.

- Одоохон гэдэс дотор урвах нь - гэж Сэм хэлэв.

Фродо дуугарсангүй. Хар дарсан аймшигт зүүднээс сэргэж чадахгүй байгаа мэт санагдана. Энэ хооронд өглөөний гэгээ ороход эмчлэгдэшгүй болтлоо эвдэрсэн газрын шарх улам ч аймшигтай тодров. Хар утаан үүлэн завсраар нар шагайсан ч нарны туяа хүртэл бузарлагджээ. Хоббитууд нар үзээд баярласангүй, нар Дайсанд үйлчилж, тэр хоёрыг түүний хогон дунд мөлхөж байгаа өчүүхэн шавьж болгон харуулж байгаа мэт санагдав.

Цаашаа явах чадал тэр хоёрт байсангүй. Тиймээс амарч болохоор газар хайв. Нэгэн том үнсэн овооны ёроолд суусан боловч тэндээс амьсгал боогдом утаа саагиж, гурвуулаа ханиалгаж, амьсгаа давхцаж эхлэв. Хорлум түрүүлэн босч, нулимж, хараал тавьсаар хоббитууд руу харсан ч үгүй дөрвөн хөллөн холдоход Фродо, Сэм хоёр араас нь дагаж, төдөлгүй баруун талаасаа үнсэн овоолгоор хаагдсан том дугариг нүхэнд оров. Тэнд адилхан л хүйтэн, зэвүүн муухай, ёроолд нь тосорхог шалбаагтай байсан ч мань гурав бүхнийг харагч нүднээс нуугдав.

Өдөр тун ч удаан өнгөрч байлаа. Ам туйлын ихээр цангаж байсан ч горхиноос дүүргэж авсан дашмагтай уснаас уруулаа чийглэх төдий суув. Тэр горхи болон хадан хонхор одоо тэр гуравт диваажин шиг л санагдаж байлаа. Хоббитууд ээлжээр унтав. Эхлээд хэн нь ч унтаж чадахгүй байсан ч нар хүнд хар үүлэнд халхлагдахад Сэм зүүрмэглэж эхлэв. Тиймээс Фродо харуул харах боллоо. Тэр дээш харан хэвтээд, тэнгэр өөд харж байтал хачирхалтай сүүдрүүд үзэгдэв. Морьт дайчид хурдлан давхилдаж, хагас мартагдсан царайнууд үзэгдэх ч шиг. Тэр цагийн баримжаа алдаж, зүүрмэглээд тэр дорхноо нам унтжээ.

Сэм нүдээ нээв. Эзэн нь түүнийг дуудах шиг санагджээ. Гэвч Фродо нүхний ёроолд унтаж байлаа. Хажууд нь Хорлум сууж байна. Тэр Фродог сэрээх гэж байна гэж Сэм бодтол тийм биш ажээ. Хорлум өөрөө өөртэйгөө ярьж байв. Смеагорл хэн нэгэнтэй маргаад байгаа бололтой, тэрний дуу хоолой шуухитнаж, шивэгнэж, түүний нүдэнд нэг цагаан, нэг ногоон гал гялалзана.

- Смеагорл андгай тангараг тавьсан – гэж нэг нь хэлэв.

- Тийм ээ, тийм эрдэнэ минь, бид эрдэнээ хамгаалж, түүнийг тэрэнд хэзээ ч өгөхгүй гэж андгайлсан. Гэвч бид тэрэнд алхам алхамаар ойртоод байна шүү дээ. Хоббит бидний эрдэнийг яах гэж байгаа нь тун ч сонихон байна, бидэнд сонихон байна.

- Мэдэхгүй. Тэгээд яах ч арга алга. Тэр эзэнд байгаа. Смеагорл эзэнд туслахаар амласан.
- Тийм ээ, тийм, бидний эрдэнийн эзэнд тусална гэж амласан. Хэрэв бид эззэн болвол өөрссөндөө туслаад, бас амлалтаа биелүүлнэ.
- Гэвч Смеагорл маш их дуулгавартай байна. Сайн хоббит! Тэр Смеагорлын хөлнөөс харгис муухай хүлээсийг авсан. Тэр надтай сайнаар ярьдаг.
- Маш их дуулгавартай, тийм үү, миний эрдэнэ? Загас шиг дуулгавартай, гулссамхай байна. Өөрөө өөрийгөө сонссоно! Гэвч бид сайн хоббитод муу юм хийхгүй, тгтиймээ, яассан ч хийхгүй.
- Би эрдэнээрээ тангарагласан
- Тэгвэл өөртөө ав л даа, тэгээд тангаргаа биелүүл! Өөрөө эрдэнийн эзэн бол, хорлум! Тэгвэл өөр нэг хоббит, ууртай, муухай ааштай, хартай хоббит, бидний хөл доор мөлхөнө, хорлум!
- Сайн хоббитыг яах ч үгүй биз дээ?
- Үгүй ээ, шаардлага гарахгүй бол яах ч үгүй. Тэр чинь ямар ч гэсэн Торбинс шүү дээ, эрдэнэ минь, тийм ээ тийм, тэр бол Торбинс. Торбинс биднээс эрдэнийг минь хулгайлсан. Тэр түүнийг олчихоод бидэнд юу ччч хэлээгүй. Өөдгүй муу Торбинсууд!
- Гэвч энэ бол тэр Торбинс биш шүү дээ!
- Бүх Торбинсууд өөдгүй муухай амьтад. Бидний эрдэнэ бидэнд хэрэгтэй!
- Гэвч тэр харна шүү дээ, тэр мэдчихээд түүнийг биднээс булааж авна!
- Тэр бүхнийг хардаг, бүхнийг мэддэг. Тэр бидний тэнэг амлалтыг сонссон – бид түүний тушаааалыг зөрчсөн. Түүнийг бид авах хэрэгтэй. Хий үзэгдлүүд хаа сайгүй шиншилж байна. Түүнийг авах хэрэгтэй!
- Гэхдээ Түүнд өгөхгүй!
- Үгүй шүү, эрдэнэ минь. Өөрөө бодоод үзээч, эрдэнэ минь, тэр биднийх болсон хойно бид түүнтэй хамт нуугдахх хэрэгтэй. Магадгүй, бид бүгдээс хүчтэй, хий үзэгдлүүдээс ч хүчтэй болно. Бөгж эзэгнэгч Смеагорл? Хэнтэй ч эгнэшгүй Хорлум! Хорлумуудын Хорлум! Өдөр болгон загас иднэ, өдөрт гурван удаа шинэхэн, амттайхан тэнгисийн загас иднэ. Хамгийн сайхан Хорлум! Түүнийг авах хэрэгтэй. Хххурдалл, хххурдалл, хххурдалл!
- Гэвч эд хоёулаа шүү дээ. Тэд хурдан сэрээд биднийг алчихна. Одоо биш, эрт байна. Тэсье – хэмээн Смеагорл гаслав.
- Хххурдалл, бид эрдэнээ их ссанассан! Гэвччч... гэвч одоо бишшш үү? Одоо биш ээ. Тэр бидэнд тусална.

- Үгүй ээ! Тэгж болохгүй! - хэмээн Смеагорл гонгинов.

- Тийм ээ! Одоо бидэнд тэсэх тэвчээр алга! алга!

Хорлум ярих бүрт урт сарвуу нь Фродо руу аажмаар сарвайж, Смеагорл ярьж эхлэнгүүт арагш татаж байв. Эцэст нь чичигнэсэн урт хуруутай хоёр сарвуу Фродогийн хоолой руу дөхөв.

Сэм чимээгүй хэвтээд, Хорлумын хөдөлгөөн бүхнийг нүд салгалгүй ажиглан яриаг нь анхааралтай сонсч байв. Урьд нь тэр Хорлум хэт өлсгөлөн амьтан учир зүүрмэглэх юм уу, өчүүхэн сэрэмж алдахад л бид хоёрыг алаад түүхийгээр нь идчихнэ гэж болгоомжилдог байв. Гэтэл одоо бүр хамаагүй их аюултай болохыг нь ойлгов. Хорлумыг бөгж тэсэхийн аргагүй татаж чангааж байна. Энэ бол Хар эзэн харж байна гэсэн үг. Гэвч тэр бидэнд тусална гэж хэнийг хэлэв? Хогийн амьтан Хорлум бас нэг өөр шигээ юмтай холбоотой байх нь ээ?. Сэм энэ бодлоо түр орхихоос өөр аргагүй болов. Саад хийхгүй бол бүр болохоо байчихаад байлаа. Сэмийн гар хөл тугалга цутгачихсан юм шиг байсан ч хүчлэн өндийж, суугаад юу ч сонсоогүй, үзээгүй дүр эсгэн чангаар эвшээж:

- Хэдэн цаг болж байна аа? – гэж нойрмог дуугаар асуув.

Хорлум шүднийхээ завсраар сийгүүлэн исгэрч, дайрах шинжтэй биеэ хөвчилснөө тэр дорхноо шалчийж, эвхэрч унаад, нүхний амсар руу мөлхөв.

- Сайн хоббитууд! Сайн Сэм минь! Нам унтчихжээ, хэтэрхий их унтчихаж! Ганцхан дуулгавартай Смеагорл ганцаараа харуул харж байлаа! Аль хэдийн орой болчихсон. Харанхуй болж байна. Явах хэрэгтэй.

“Тэгнэ байх аа, чи! Эрхэм цаггалан нөхөр минь, чамаас салах цаг ч болсон” гэж Сэм дотроо хэлэв. Гэвч тэр дороо бодол нь өөрчлөгдөж, Хорлумыг хараа хяналтаасаа салгалгүй дагуулж явах хэрэгтэй гэсэн санаа төрөв.

- Алга болоод өгөөсэй! Аль газрын гай вэ бас! – хэмээн бувтнасаар тэр доош бууж, эзнээ сэрээв.

Фродо ханатлаа унтаж, сайхан зүүд зүүдэлжээ. Хар сүүдэр алга болж, сүйрсэн энэ хязгаарын тэг дунд холын сайхан орнууд харагджээ. Ой тойнд нь тодорхой юм юу ч үлдээгүй ч санаа сэтгэл сэргэж, ачаа нь хөнгөрсөн байлаа. Хорлум нохой мэт баярлан, хөхөрч, шулганаж, урт хуруунуудаа тас тас инчдэн, Фродогийн өвдгийг илэв. Цаадах нь түүн рүү инээмсэглэв.

- Сайн, сайн. Чи их сайн байна, найдвартай газарчин. Бид бараг зорьсон газраа ирж байна. Биднийг хаалганд хүргэчих, цаашаа хэрэггүй. Хаалганд хүрээд л дуртай газар руугаа яв, харин бидний нийтийн дайсан руу л битгий яваарай.

- Хаалга руу гэв үү? -гээд Хорлум айсан, гайхсандаа часхийтэл хашгираад:

- Эзэн хаалганд хүргэ гэж байна. Тийм ээ, тэр тэгж хэлсэн, харин дуулгавартай Смеагорл эзний хэлсэн бүгдийг хийнэ. Тийм ээ тийм. Ойртож очоод эзэн бодлоо өөрчилж ч болно,

харж байж больё. Тэр хаалганы тэнд сайн юм юу ч байхгүй. Огтхон ч байхгүй!

- За за, чамаас асуухаа мартчихаж л дээ, чи зүгээр л дагуулаад яв! - гэж Сэм хэлэв.

Тэд бүрэнхий дундуур нүхнээс гараад, удаан, ихэд болгоомжтой урагшиллаа. Дахиад л айдас тэднийг газарт наав. Намаг дунд явахад үзэгдсэн аймшигт хар далавчит мангас гараад ирэв. Тэд хуурай, муухай үнэрт газарт наалдан хэвтсэн боловч Барад-Дурын элч хажуугаар өнгөрөв бололтой, тэнгэр харанхуйлсангүй. Эцэст нь Хорлум босч, чичирч дагжин хамар дороо нэг юм гонгиносоор цааш хөдлөв.

Шөнийн нэг цагийн орчимд хар мангас дахин тэднийг газарт наасан боловч энэ удаа ч гэсэн холуур, үүлэн дээгүүр баруун зүгийг чиглэн шуугин одов. Гэвч Хорлум айсандаа хөдөлж ч чадахаа болив. Хар мангас тэднийг зорьж ирсэн гэж тэр боджээ.

- Гурван удаа! Бүтэн гурван удаа! Тэд биднийг мэдэрсэн байна, мэдэрсэн байна. Тэд бол эрдэнийн зарц нар. Бид цаашаа явж болохгүй. Биднийг бариад авна!

Тэрнийг тайвшруулж, ятгах гэж нэлээд оролдов. Эцэст нь Фродо түүн рүү хашгирч, илднийхээ бариулаас шүүрэхэд тэр бөглүү урхиран босч, зодуулсан нохой шиг урд нь орон шогшив.

Зовлонтой удаан шөнийг дуустал тэд юу ч сонсолгүй, юу ч харалгүй харанхуй дундуур бэдрэв. Зөвхөн салхи л чихэнд заналтай исгэрч байлаа.

Бүлэг 13

Хориотой хаалганы дэргэд

Тэд үүрээр Мордорт дөхөж ирэв. Намаг, цөл хоёр ард хоцорч, өмнөөс нь сүрлэг оргилуудаа тэнгэр өөд өргөсөн хар уулс бараантаж харагдав. Мордорын баруун талаас Эфель-Дуат буюу Изгарын нуруу хааж, хойт талаас нь Эред-Литуин үнсэн саарал өнгөт уулс хааж, хоёулаа нийлээд Литлад ба Горгоротын үнс болтлоо шатсан өргөн тал руу нэвтрэхийн аргагүй хана хэрэм үүсгэжээ. Баруун хойт талд нь энэ хоёр нурууны уулзварт гүн хавцал үүссэн нь Кирит-Горгор буюу Дайсны газарт нэвтрэх цорын ганц хаалга болсон Хий үзэгдлийн хавцал ажгуу. Хавцлын хоёр талаар эгц өндөр хар хясаанууд дээр Мордорын соёо хэмээн нэрлэгдсэн нүсэр өндөр цамхгууд сүндэрлэжээ. Эдгээр цамхгийг тэртээ дивангарт, Гондор гүрэн хүчирхэгжин мандаж, Саурон ялагдан энэ хязгаараас хөөгдсөний дараа босгожээ. Хар эзэн эргэж ирэх тухай бодоо ч үгүй байсан боловч Гондор гүрэн доройтож, гондорчууд залхуу хойрго болж, харуулын цамхгууд хэдэн зуун жил эзэнгүй болсон ажээ. Дараа нь Саурон эргэн ирж, эдгээр цамхгуудыг шүдээ хүртэл зэвсэглэсэн цэргүүдээрээ дүүргэжээ. Цамхгуудын харанхуй хар нүд –цонхнуудаас мянга мянган нүд хойт, зүүн, баруун зүг рүү хором ч алгасалгүй хардаг болсон түүх ийм аж.

Хар эзэн хавцлыг цорын шанц ширмэн хаалгатай асар том хэрмээр хааж, хөрөөний ир шиг сэрийсэн орой дээгүүр нь өдөр шөнөгүй харуулууд зөрөлдөн манадаг болсон байна. Хадан уулсын бэлээр олон зуун агуй нүхлэн ухаж, хар шоргоолжны үүр мэт буцалсан тоймгүй олон орхууд хэзээ ямагт байлдаанд бэлэн язганаж байдаг болсон ажгуу. Мордорын соёонуудын хоорондуур зөвхөн Сауроны дуудсан этгээд юм уу, хар хаалгыг нээх нууц тарнийг мэддэг этгээд л нэвтгэрдэг болжээ.

Хоббитууд цамхаг, хэрмийг цөхөрсөн нүдээр ширтэн зогсов. Тэртээ алсаас, үүрийн саарал гэгээнд ч хаалганы дэргэдэх харуулууд, хэрэм дээрх харуулууд харагдаж байв. Тэр гурав Эфель-Дуатын хойт үзүүрийн уулан дорх хонхроос тийш харж байлаа. Тэндээс хамгийн ойрын цамхаг хүртэл хэрээ нисгэвэл хэдэн зуун сажин нисэх зайтай байв. Цамхаг дээгүүрх аварга том яндангаас асар их хар утаа савсана.

Өдөр болж, Эред-Литуин ясархаг ирмэг дээгүүр хүрэн улаан нар гарч ирэв. Харуулын цамхагууд дээрх яндангууд гэнэт орилж, уулс, хавцал, хаа сайгүй газраас үл үзэгдэгч хуарангуудыг сэрээн, тэртээ Барад-Дурт бөмбөрүүд нижигнэн, бүрээнүүд ульж, үхмэл нүцгэн талаар үл замхрах заналт цууриа нисэн тарав. Мордор шинэ өдрийн хүнд хүчир хөдөлмөр, зүрх зүсэм аймшгаа угтаж байгаа нь энэ ажгуу. Шөнийн эргүүлүүд, харуул манааг хадан нүхнүүдээр тарааж, оронд нь сэргэг, улаан галзуу халаа авлаа. Хэрмийн ханан дээрх шагайвчуудаар ган төмөр бүдэгхэн гялалзаж харагдана.

- Ээ хөөрхий зайлуул, ингэдэг юм биз дээ! Хаалган дээр нь амиараа дэнчин тавьж арай гэж хүрээд ирсэн чинь биднийг ороод ир гэж урихгүй, буцаад загтаах боломж өгөхгүй нь илэрхий болов оо. Одоо би Жихарийн нүдэнд харагдах юм бол тэр хэлэх үгээ олох л юм байна! Хичнээн ч удаа надад Сэм минь өөртөө битгий нүх ух, хэн ч гаргаж ирэхгүй гэж хэллээ дээ!

Нээрэн тэгж хэлдэг байсан юм шүү. Одоо ч дахиж хэлэхгүй биз дээ. Бид хоёр дахиад уулзахгүй нь илт байна. Үгэнд нь орж байх минь яв даа - Өдөр болгон үглүүлж дуулуулаад, элдүүлж нухлуулаад байсан бол эцгийгээ би харж баярлаж явах байлаа. “Сэм, хүү минь чиний толгой ч цэцэрлэгийн толгой юм аа...” гэж магтах байсан даа. Гэхдээ эхлээд гар нүүрээ сайн угаахгүй бол тэр намайг танихгүй нь мэдээж л дээ. Одоо бид хаашаа явах вэ гэж асуух хэрэг байхгүй. Одоо бид хаашаа ч явахгүй, ямар орхуудаас бидэнд газарчлаад өгөөч найзууд минь гэж гуйлтай биш дээ! – хэмээн Сэм үглэж гарав.

- Үгүй шүү, үгүй! Орхуудаас гуйх хэрэггүй. Цааш явж болохгүй. Смеагорл тэгж хэлсэн шүү дээ. Тэр хаалганд дөхөж очоод харъя гэж хэлсэн. Тийм ээ, миний эрдэнэ минь, харъя, үзье. Хоббитууд энд явах газар байхгүй гэж Смеагорл мэдэж байсан, тэрийг ч харин Смеагорл ёстой мэдэх байх шүү - гэж Хорлум цэхэлзэв.

- Ямар чөтгөрөө хийх гэж чи бид хоёрыг ийш нь дагуулж ирэв? – гэж тэнэг бөгөөд утгагүй асуулт тавилаа.

- Яагаад гэвэл эзэн тушаасан. Эзэн биднийг хаалган дээр хүргээд өг гэж хэлсэн. Тэгээд л Смеагорл тушаалыг биелүүлсэн. Эзэн мэдэж байгаа, тэр мэргэн ухаантай.

- Тийм ээ, би тэгж тушаасан – гэж Фродо хэлсэн боловч царай нь баргар, ширүүн бөгөөд шийдэмгий байлаа. Шавар шалбааганд хутгалдаж, туйлдаж ядарсан боловч тэр эгцхэн зогсч, нүд нь хурцаар гялалзаж харагдав.

- Мордор руу орох хэрэгтэй байсан учраас би тэгж тушаасан. Тийшээ орох өөр замыг би мэдэхгүй. Тэгэхлээр энэ замаар л явна. Харин би ганцаараа явна.

- Үгүй шүү үгүй, эзэн минь! – хэмээн Хорлум хашгирч, үхтлээ айсандаа Фродогийн хормойноос санд мэнд зуурч:

- Энэ замаар явж болохгүй! Хэрэггүй шүү! Эрдэнийг түүнд өгч болохгүй! Тэрний гарт эрдэнэ орвол тэр биднийг бүгдийг нь залгичихна, бүх ертөнцийг залгина. Эрдэнийг өөртөө үлдээ, эзэн минь, Смеагорлыг өрөвд. Эрдэнийг минь эзэмш, харин тэрний гарт л оруулж болохгүй. Эсвэл дуртай газар руугаа яв, харин эрдэнийг хөөрхий Смеагорлд буцаагаад өгчих. Тийм шүү, эзэн минь, өгчих тэгэх үү? Смеагорл түүнийг нуучихна, оршуулчихна, Смеагорл зөндөө олон сайн үйл бүтээнэ, ялангуяа сайн хоббитуудын төлөө. Харин хоббитууд гэр рүүгээ явна. Хаалга руу битгий яваач!

- Мордор руу яв гэж надад тушаасан, тэгэхлээр явах л хэрэгтэй. Тийшээ орох ганцхан л зам байна, тэгэхлээр саатаад яахав. Юу л болбол болог.

Сэм дуугарсангүй. Дэмий үгээр юугаа хийх билээ, эзний царайд тэртэй тэргүй бүх юм бичээстэй байна. Тэгээд ч тэр бүр эхнээсээ энэ хачин аяны эцэст сайн юм юу ч болохгүй гэдгийг мэдэж байсан юм чинь, одоо өнгөрсөн хойно гомдох юм алга. Одоо аян дуусч байна, би эзэнтэйгээ хамт байна, эзэн минь миний дэргэд байна, тэр хаашаа, би тийшээ, хичнээн урт замыг хамтдаа туулав даа, эцэст нь салж одох гэж түүнтэй зууралдсан юм уу? Мордор руу тэр ганцаараа орж болно гэж үү? Тэр хаашаа, Сэм тийшээ, харин Хорлум дуртай зүгтээ явж

зугаална биз.

Гэвч Хорлум явж зугаалах бодолгүй байгаа бололтой. Тэр Фродогийн хөлийг тойрон мөлхөж, хуруу гараа нугалан, гасалж гийнаж байна.

- Тийшээ энэ хаалгаар орж болохгүй. Эзэн минь! Өөр зам байгаа. Тийм ээ тийм, огт өөр зам. Харанхуй, нууц, харагдахгүй зам. Смеагорл тэр замыг мэднэ. Зөвшөөрчих, Смеагорл чамд тэр замыг үзүүлье!

- Өөр зам гэнэ ээ? - хэмээн Фродо Хорлум руу итгэлгүй харж асуув.

- Тийм ээ-шшш! Огт өөр зззам, Смеагорл тэрнийг эрж олсон юм. Явцгаая, одоо байж ч магадгүй!

- Чи урьд нь тэр тухай яриагүй шүү дээ.

- Үгүй ээ, эзэн өөрөө асуугаагүй шүү дээ. Эзэн хаашаа явж байгаагаа хэлээгүй, хөөрхий Смеагорлд нэг ч үг дурсаагүй. Тэр, Смеагорл, намайг хаалганд хүргэж өгөөд хурдхан буц! - гэж хэлсэн. Смеагорл буцах л байсан, гэвч тэр сайн, сайхан сэтгэлтэй болсон. Одоо эзэн - Би Мордор руу орно гэж байна. Смеагорлд маш их аймшигтай байна. Тэр сайн эзнээ алдахыг хүсэхгүй байна. Тэр тангарагласан, эрдэнийг аварна гэсэн түүний ам тангаргийг эзэн авсан. Одоо эзэн Түүнд баригдаж, тэр эрдэнийг хар хуруундаа зүүнэ. Смеагорл эзнээ аварч, эрдэнээ хадгалахыг хүсч байна. Тэгээд л урьд нэг удаа явж байсан өөр замыг саналаа. Сайн эзэн минь. Смеагорл сайн, дуулгавартай, тэр туслахыг хүсч байна.

Сэм хөмсөг зангидан царай барайлгав. Түүний хоёр нүдний оронд шөвөг байсан бол Хорлумыг нэвт шөвөгдөх байв. Хорлумын яриа тун ч их эргэлзээтэй байлаа. Хорлум үнэнээсээ айж, санаа зовж, Фродод туслахыг хүсч байгаа юм шиг. Гэвч тэр өөртэйгөө яаж ярьж байсныг Сэм санаж байлаа. Хоёр гуравхан хоногийн өмнө дахин төрсөн Смеагорл хорлумыг ялсан гэж үү? Тэгээд ч тэр ярианд сүүлчийн үгийг Хорлум хэлсэн шүү дээ. Сэмийн бодлоор бол Смеагорл, Хорлум (Сэм дотроо тэр хоёрт Наалдаахай, Өмхий гэсэн нэр хайрлачихаад байв) хоёр эвлэрч, тохиролцсон байх. Фродо баригдаж, бөгж Дайсны гарт орохыг аль аль нь хүсэхгүй, цагийг нь болтол Фродотой наалдаж байгаад боломж гармагц эрдэнээ авах гэж төлөвлөсөн байлаа. Харин Мордор руу орох өөр замын тухайд бол ёстой гай нь ирээгүй бол гайгүй байлгүй.

“Эзэн яах гэж Мордор руу зүтгээд байгааг энэ хоёрын аль нь ч мэдэхгүй байгаа нь сайн хэрэг. Ноён Фродо тэдний эрдэнийг үгүй хийх гэж байгааг мэдэх юм бол ч чононд хонь уяж өгсөнтэй адил юм болно биз! Өмхий Дайснаас амиа гартал айж байгаа, цаадах нь энийг хараан дороо, андгай тангаргийг нь авч байж явуулсан байж таарна. Өмхий өөрөө тэрнийхээ гарт орохгүйн тулд бид хоёрыг нүд ирмэх зуурт гэдэс дотортой минь хамт зарчихна, бас эрдэнээ галаас авчихна гэж бодож байгаа. Би ингэж ойлгож байна. Эзэн маань үүнийг ойлгож байгаа бол сайнсан. Эзний ухаанд байгаа бодлыг захын Скромби зүгээр л гараараа нээгээд харчихна. Өмхийн хэлдгээр хэтэрхий сайхан сэтгэлтэй амьтан шүү дээ” – гэж Сэм сэтгэж байлаа.

Фродо Хорлумд шууд хариулсангүй. Сэм удаавтар боловч зөв сэтгэж, бас эргэлзэж байх хооронд тэр Кирит-Горгорын хар цохиог ширтэн дуугүй зогсч байлаа. Тэдний байгаа хонхор Мордорын баруун харуулын цамхгийн хананы дэргэдэх гүн шуудууны цаадах намхан уулын хажууд байв. Өглөөний гэгээнд Мордорын хаалганаас гарсан тоост замууд тод үзэгдэж байв. Нэг нь хойт зүг рүү тахиралдан одож, нөгөө нь зүүн зүг рүү, Эред-Литуины бэлд буусан мананд далдарч, гурав дахь нь цамхгийг ороогоод, Эфель-Дуатын баруун хажуу өөд гарчээ.

Фродо эргэн тойрноо харж байгаад Дагорладын тал тэр чигээрээ буцалж байгааг ойлгов. Хаа сайгүй цэргүүд намгийн манан, угаан хөшгөнд нуугдан хөдөлж байна. Хуяг дуулга, жадны үзүүр гялалзаж, тал бүрээс морьт цэргүүд ирж байна. Хязгааргүй уудам дорнын газар бүрээс элдэв янзын цэргүүд эзнийхээ дуудлагаар ирж байна.

Тоо томшгүй язганасан дайснуудын дунд, бараг нүдэнд нь ил ганцаараа зогсч байгаагаа, амь нас нь хялгасанд дүүжлэгдэж байгаагаа гэнэт ойлгосон мэт Фродо хөнгөн саарал юүдэнгээ өмсч, хонхор руу ороод Хорлумд хандаж:

- Смеагорл, би чамд дахиад нэг итгэе. Тэгэх хэрэгтэй юм шиг байна. Би чамаас тусламж авна гэж огт хүлээж байгаагүй боловч тэгэх тавилантай юм байна, харин чи урьд өмнийн хар хорон нүглүүдээ цайруулахын тулд надад туслах тавилантай юм шиг байна. Одоогоор би чамайг буруутгах юм юу ч алга. Чи өөрийнхөө андгайг нэр төртэй биелүүлсэн, бид хоёр ч удаа чиний эрхэнд орсон, гэвч чи бид хоёрт халдаагүй. Чамд хамгийн их хэрэгтэй ганц зүйлээ надаас булаах хүсэлдээ автагдаагүй. Гурав дахь удаад битгий автагдаарай! Тэгээд чи маш их аюул дор байгаа гэдгээ битгий мартаарай.

- Тийм ээ тийм, эзэн минь! Аймшгийн аюул дор байгаа! Смеагорлын бүх шөрмөс чичирч байна, гэвч тэр зугатахгүй. Тэр сайн эзэндээ туслах хэрэгтэй гэдгийг мэдэж байна.

- Би бид бүхнийг бүгдийг нөмөрсөн аюулын тухай яриагүй, аюул чамайг л хамгийн аймшигтайгаар нөмөрч байна. Чи эрдэнээрээ тангарагласан, чи юуг тэгэж нэрлэж байгааг би хэлэхгүй. Тогтоож ав. Тэр эрдэнэ чинь чамайг тангаргаа биелүүлэхийг шаардаж байгаа, гэвч тэр чамайг бас сүйрүүлж чадна. Тэр аль хэдийн чамайг оролдож эхэлсэн. Чи сая өөрийн эрхгүй надад өөрийгөө тэнэгээр илчилсэн. “Түүнийг Смеагорлд буцаагаад өгчих” – гэж хэлсэн шүү. Энэ үгээ дахиж битгий давтаарай! Энэ тухай бодлоо хөөн тонилго! Чи түүнийг хэзээ ч буцааж авахгүй. Хэрэв хар шидийн хүч чамайг эзэмдвэл чи үхнэ. Чи тэрнийг хэзээ ч буцааж эзэмшихгүй, Смеагорл, хэрэв өөр зам байхгүй болбол би чиний эрдэнэсийг зүүнэ, эрдэнэс чамайг аль эрт эзэмдсэн байгаа. Би тэрнийг зүүнгүүтээ би чамд тушаал өгнө, чи миний тушаалыг биелүүлнэ, би чамайг ангал руу харай гэвэл чи харайна, гал руу ор гэвэл чи орно. Болгоомжлоорой, яагаад гэвэл би тэгж тушааж байна. Болгоомжтой байгаарай, Смеагорл.

Сэм эзэн рүүгээ гайхан харав. Тэр хэзээ ч ийм юм ярьж, хэзээ ч ийм харагдаж байсныг тэр мэдэхгүй. Тэр эрхэм эзэн Фродо хэтэрхий сайхан сэтгэлтэй, тэрнээсээ болоод алдаж байдаг гэж боддог байлаа. Гэхдээ төрөлх ухаанаараа бол энэ ертөнцийн хэнбугайгаас ч илүү (хөгшин ноён Бильбо болон Гэндальфыг гүйцэхгүй байж болох юм) гэдэг нь Сэмд аяндаа мэдэгдээд байдаг байв. Хорлум Фродотой танилцсанаас хойш ердөө тав хонож байгаа учир “сайн эзэн”-ийг хурууны үзүүрээр хуурч дөнгөнө гэж бодсон нь эндүүрэл болж, түүний саяны хэлсэн үг

толгой дээр нь муна буулгах шиг болж, ухаангүй айлгав. Тэр газраар элэглэн мөлхөж, арай ядан “сайн эзэн” гэсэн хоёр үг амнаасаа гаргалаа.

Фродо түүний тайвшрахыг хүлээж хэсэг зуур дуугүй байснаа арай зөөлнөөр:

- За тэгээд Хорлум нь ч байна уу, Смеагорл нь ч байна уу, тэр өөр зам чинь ямаршуу зам юм бэ, тэр зам энэ замаас юугаараа илүү найдвартай вэ? Чадвал тайлбарлаад өг. Харин түргэлээрэй, би яарч байна шүү.

Гэвч Хорлумыг харахад ч өрөвдмөөр байв. Фродогийн хэлсэн үг түүнийг бүр алийг нь алдуулжээ. Юун тайлбарлахтай манатай. Тэр эхэр татан уйлж, гасалж гийнан, элгээрээ мөлхсөн хэвээр, “Хөөрхий Смеагорлыг өрөвдөөч” хэмээн дахин давтан үглэсээр байв. Эцэст нь арай гэж жаахан чимээгүй болсны дараа Фродо түүнээс үг үгээр, бага багаар сугалсаар тэр зам нь Эфель-Дуатааас баруун зүг эргэж, дараа нь өмнө зүг рүү эргэвэл өтгөн шугуй дундах жимийн уулзварт хүрнэ гэж мэдэж авлаа. Жим баруун тийш эргэж Осгилиат болон Андуины гүүрнүүд рүү хөтлөх ба дунд гүүрээр гарвал өмнө зүг рүү явах ажээ.

- Цаашаа, цаашаа, цаашаа – гэж Хорлум давгаад:

- Бид тэр замаар яваагүй, гэхдээ нэг зуун бээр яваад Их усанд хүрнэ. Тэнд зөндөө зөндөө загас байдаг, том том шувуунууд тэр загаснуудыг барьж иддэг гэж сонссон, амттайхан шувуунууд гэсэн шүү, даанч бид тэнд нэг ч удаа очиж байгаагүй, дэндүү хол. Түүнээс цааш огт өөр газар орон байдаг, тэнд Шар хоншоор маш их хаздаг, үүл бараг байхгүй, хар царайтай хүмүүс нь их хэрцгий гэсэн. Бид тийшээ явахыг хүсэхгүй байна.

- Хүсэхгүй байна гэнэ ээ бас, тийшээ явахыг би ч хүсэхгүй байна, гэвч чи шал өөр юм яриад байна, гурав дахь зам нь ямар зам юм бэ? – гэж Фродо зандрав.

- Тиймээ, гурав дахь зам бий, зүүн тийшээ явдаг зам. Тэр зам шууд уул өөд гараад, муруйж тахирласаар бүр их өндөрт саарал сүүдэрт орно. Тэгээд хар хясааг тойроод, гэнэт яг дээр байгааг харна, тэгээд хаана ч хамаагүй нуугдахыг хүснэ.

- Юуг харах юм бэ? Юу яг дээр байх юм бэ?

- Хуучин цайз, маш хуучин, одоо маш аймшигтай болсон. Бүр эрт цагт, Смеагорлыг жаахан байхад өмнийн олон үлгэр байсан. Тийм ээ, орой үдэш Их мөрний эрэг дээр, бургасан дор суугаад үлгэр яриад л, яриад л байдаг байсан, мөрөн тэгэхэд огт өөр байсан, хорлум хорлум.

Тэр хи-хи хөхөрч, гоншгонож, амандаа юу ч юм бувгналаа. Хоббитууд тэвчээртэй хүлээж байв.

- Тийм ээ, өмнөдийн үлгэр – гэж эцэст нь хорлум яриагаа үргэлжлүүлэв: - Хурц нүдтэй өндөр хүмүүсийн тухай, тэдний уул шиг өндөр чулуун байшингийн тухай, мөнгөн титэмтэй хаадын тухай, бас цагаан модны тухай сайхан үлгэрүүд. Хүмүүс тэнгэрт тулсан цамхгууд барьсан, хамгаас өндөр мөнгөлөг цагаан цамхаг байдаг, түүн дотор сарны чулуу байдаг, эргэн тойронд нь өндөр цагаан хана байдаг.

- Энэ лав Минас-Итилийн тухай ярьж байх шиг байна, түүнийг Мандах сарны цайз гэж нэрлэдэг, Элендилийн хүү Исулдур бариулсан гэдэг юм. Дайсны бөгжтэй хурууг тас цавчсан тэр Исулдур – гэж Фродо өгүүлэв.

- Тийм, тийм, хар гарт дөрвөн хуруу байсан – гэж Хорлум хэлээд дагжин чичирч: - Гэхдээ түүнд дөрвөн хуруу хангалттай. Исулдурын цайзыг тэр үзэн яддаг.

- Тэр бүх юмыг үзэн яддаг, гэвч бидэнд мандах нарны цайз ямар хэрэгтэй юм бэ? – гэж Фродо асуув.

- Эзэн минь, эзэн минь, тэр цайз байсан хэвээрээ л байж байгаа. Өндөр цамхаг, цагаан байшингууд, цайзын хэрэм бүгд бий. Харин хэрэм нь муухай болсон. Тэр хэрмийг маш эрт эзэлсэн, одоо тэнд маш аймшигтай. Харсан болгон мөлхөж, холхон нуугдмаар болдог. Гэвч эзэн тэр замаар явахаас аргагүй, яагаад гэвэл өөр зам байхгүй. Тэнд уул намхан болно, хуучин зам уулын оргил хүртэл, харанхуй даваа хүртэл явна, дараа нь доошоо, доошоо, Горгорот хүртэл явна – гээд тэр чичирч, шивнэн ярив.

- Тэгээд юу гэж? Дайсан тэр уулыг дөрвөн хуруу шигээ мэдэж байгаа, тэр замыг энэ замаас дутуугүй хамгаалж байгаа биз дээ? Цамхаг хоосон биш биз дээ? – гэж Сэм асуув.

- Хоосон биш ээ, хоосон юм шиг санагдавч хоосон биш, тэнд аймшиг байрласан. Орхууд ч байгаа, тэд хаа сайгүй байдаг, гэхдээ тэнд орхуудаас хамаагүй аймшигтай. Зам хэрмэн доогуур, харанхуйгаар явж хаалганд хүрдэг. Замыг хэрмэн дотроос чимээгүй тагнуулууд манаж байдаг.

- Зөвлөгөө өгсөнд баярлалаа, бид өмнө зүг рүү өчнөөн хол аялаад эндээс ч илүү аймшиг дунд яваад орчих юм байна – гэж Сэм хэлэв.

- Үгүй шүү, үгүй. Хоббитууд бодож үз, тунгааж үз. Тэр тэндээс хэн ч орж ирэхгүй гэж бодож байгаа. Тэрний нүд хаа сайгүй тэмтэрч байдаг боловч бүгдийг шууд харж чадахгүй. Тэр Изгарын уулнаас мөрөн хүртэлх газрыг аль эрт эзэлсэн, одоо гүүрнүүдийг эзэлсэн болохоор Сарны цамхаг хүртэл зөвхөн гүүрээр юм уу завиар л явж очно гэж бодож байгаа, завийг нууж болохгүй учраас тэр харна.

- Чи ч тун их юм мэдэж байна даа. Тэр хаашаа харж байгааг, юу бодож байгааг гээд л... Саяхан тэрэнтэй уулзсан юм уу, эсвэл орхуудтай сүлбэлдсэн юм уу?

- Муу хоббит, тэнэг – гэж Хорлум хэлээд Сэм руу ууртай хялалзан дахин Фродод хандаж: - Смеагорл мэдээж орхуудтай ярилцсан, орхууд төдийгүй бүгдтэй ярилцаж, асууж байсан. Смеагорл олон газраар тэнэсэн. Гэхдээ эзэнтэй уулзахаас өмнө. Тэгээд юу олж сонссоноо одоо ярьж байна. Тэр энэ хойт талд хамгаас их аюултай гэж мэдэж байгаа, тиймээс бидэнд энэ зам аюултай. Одоо удахгүй тэр хар хаалгаар гарч ирнэ, зөвхөн тэндээс л их олон цэрэг гаргаж болно. Харин баруун өмнө талд тэр довтолгооноос айхгүй байгаа. Тэнд зөвхөн чимээгүй тагнуулууд л манаж байгаа.

- Ямар ялгаа байна! Тэнд хүрч очоод хаалгыг нь тогшиж. Уучлаарай, энэ хаалгаар Мордор руу

орох уу гэж асуух юм уу? Эсвэл тэд чимээгүй манаас учраас хариу өгөхгүй юм уу? Юугаа хийж долоон бээр алхасны эцэст аюултай тулгарах юм бэ, тэр аюултай энд тулгарсан нь дээр биз – гэж Сэм өөрийнхөөрөө зүтгэв.

- Хошигнох хэрэггүй, инээдтэй юм огт алга байна, тийм ээ, инээх юм огт алга – гэж Хорлум ууртай хэлээд: - Мордор руу орох хэрэг надад алга, гэвч эзэн “би орох хэрэгтэй, би орно” гэсэн болохоор зам хайх хэрэгтэй. Тэр аймшигт хэрмэн дундуур явахгүй нь мэдээж. Смеагорл түүнд тусална. Яах гэж Мордор руу зүтгээд байгаагаа хэлээгүй ч гэсэн тусална. Ганцхан Смеагорл л тэр замыг мэднэ, тэр өөрөө олсон юм.

- Чи тэндээс юу олсон юм бэ? – гэж Фродо асуухад Хорлум түүний хөлийг тэвэрч аваад дахин шивнэв:

- Хэрмийн хажуугаар уул руу нарийхан жим хөтөлдөг юм. Тэгээд маш урт, нарийхан шатанд хүрнэ. Нэг, хоёр, гурван шат, тэгээд харанхуй хонгил, тэрний цаана хадан хясааны нүх, тэгээд их өндөрт гол хаалга руу орсон жим. Тэнд Смеагорл харанхуйгаас аврагдсан. Гэхдээ олон жилийн өмнө шүү дээ. Одоо тэр жим байж ч болно, байхгүй ч байж болно.

- Энэ дэмий яриа надад ёстой таалагдахгүй байна. Юун ч амархан юм бэ, исгэрээд л алхаад байх юм биз дээ? Тэр жим нь байлаа гэж бодоход чанд хатуу харуул хамгаалалттай байж таарна. Тэр үед жимийг хамгаалж байсан уу, үгүй юу Хорлум? – гэж Сэм асуухад Хорлумын нүдэнд ногоон оч гялсхийж, ямар нэг юм битүү бувтнасан боловч дуулдахаар юм хэлсэнгүй.

- Хамгаалж байсан уу, үгүй юу? – гэж Фродо ширүүн асуув: - Чи үнэхээр харанхуйгаас аврагдсан уу, Смеагорл? Чамайг тавиад явуулчихсан юм биш үү? Даалгавар өгөөд явуулчихсан юм биш үү? Чамайг Үхдлүүдийн намагт барьж авсан гэж Арагорн бодож байгаа юм.

- Тэр худлаа! - хэмээн Горлум шуухирч, Арагорны нэрийг сонсмогц нүд нь хорслоор дүрэлзээд:

- Тэр намайг гүтгэсэн, тийм ээ гүтгэсэн байна. Би өөрөө өөрийгөө аварсан. Тийм ээ, эрдэнийг ол гэж надад даалгасан, тэгээд л би хайгаад л байсан, хайгаад л байсан, өөр яах юм бэ? Гэвч би тэрэнд – Хард өгөх гэж хайгаагүй. Эрдэнэ бол биднийх, минийх гэж би хэлээд байна шүү дээ. Би өөрийгөө аварсан.

Фродо энэ удаа Хорлум тийм ч их худлаа яриагүй, тэр Мордородоос гарах нүхийг өөрөө эрж олсон нь үнэн гэдэгт хачин итгэлтэй байв. Түүнээс гадна тэр “би”, “минийх” гэж хэлэхийг Фродо анзаарсан бөгөөд аль эрт мартагдсан үнэн, нэр төрийн ховорхон тохиолдох өчүүхэн гялбаанд тэр ингэж хэлдэг билээ. Гэвч Хорлум худлаа яриагүй байлаа ч гэсэн Фродо Дайсны хорон ухааныг мартаж орхисон байлаа. “Өөрийгөө аврах” боломжийг Дайсан далдуур зохион байгуулсан байж болох билээ. Тэгээд ч Хорлум ямар нэг юм нуугаад хэлэхгүй байгаа нь илт байв.

- Би чамаас дахиад асууя. Чиний нууц жимийг хамгаалж байгаа юу, үгүй юу?

Гэвч Арагорн гэдэг нэр л Хорлумд хурц илд байсан бөгөөд дээр нь бас түүний үнэн ярьсан

эсэхэд эргэлзэж байгаа нь бүр ч уурыг нь хүргэжээ. Худалч этгээд үнэн юм уу, хагас үнэнийг хэлэхэд үнэмшихгүй байх нь түүний хувьд хоёр дахин гомдолтой байдаг билээ. Тэр хариу хэлсэнгүй.

- Хамгаалж байгаа юу? – гэж Фродо шаардахад:

- Тийм ээ, магадгүй. Энд бүх юм хараа хяналтад байгаа. Гэвч эзэн дайсны хараанаас далдуур хаашаа ч явахгүй. Гэр рүүгээ буцсан ч ялгаагүй – гэж Хорлум бувгнав

Цааш нь түүгээр нэг ч үг хэлүүлж чадсангүй. Өндөр уулын тэр жимийн нэрийг тэр мэдэхгүй байгаа юм уу, нууж байгаа юм уу бүү мэд.

Тэр нь Кирит-Унгол нэртэй бөгөөд тун ч муугаар алдаршсан газар байлаа. Арагорн энэ нэр ямар утгатайг тайлбарлаж өгөх байсан, Гэндалф тэднийг сэрэмжлүүлэх байсан билээ. Гэвч тэр хоёрын хэн нь ч одоо дэргэд байсангүй. Тэр хоёр энэ үед Изенгардын нуранги дотор зэрэгцэн зогсч, Гэндалф урвагч Сарумантай тооцоо хийгээд хайран цагаа алдаж байв. Гэвч Гэндалф Саруманыг яллаж, палантир ортханкийн гантиг шатыг хагалж байх үед ч Фродо, Сэм хоёрыг дотроо бодож, урмыг нь сэргээн дэмжиж байсан юм.

Магадгүй Фродо өөрөө ч мэдэлгүйгээр үл үзэгдэх тэр тулгуурыг мэдэрсэн биз ээ. Овидад явж байхад ч тэр Гэндалфыг холын Мориин ёроолгүй нүхэнд амь үрэгдсэн гэж багтай итгэж байсан мөртөө ийм тулгуурыг мэдэрсэн билээ. Фродо удтал дуугүй сууж, Гэндалфын захиж хэлсэн үгсийг нэг бүрчлэн санав. Гэвч ийм тохиолдолд хэрэг болох зөвлөгөө олдсонгүй.

Тиймээс өөрөө, Хоббитанийн жирийн нэгэн жижиг биет тэрбээр шидтэнүүд болоод баатар вангуудаас илүү эр зориг, овсгоо самбаа гаргах хэрэгтэй боллоо. Түүнд тун ч бэрх тавилан ногджээ. Гэвч тэр өөрөө энэ тавилангаа өнгөрсөн оны хавар тохилог зочны өрөөндөө сонгож аваагүй гэж үү? Түүнд олигтой сонголт байхгүй. Аль замаар нь явах вэ? Хэрэв аль ч замын үзүүрт аймшиг, үхэл хоёр тосч байгаа юм бол сонгох хэрэг юу байна?

Өдөр өнгөрч өгдөггүй. Аймшгийн хаант улсын хаалганаас хоёр алхмын зайд тэдний сууж буй хонхор дээгүүр ер бусын нам гүм байлаа.

Өнгөгүй өндөр тэнгэр утаан мананы цаанаас бүдэгхэн усан мандал шиг харагдана. Тэнгэрт нисч яваа ямар ч бүргэд саарал цуваа өмсөөд хөдлөх ч үгүй сууж байгаа хоёр хоббитыг олж харахааргүй байв. Магадгүй, газарт тэрийн хэвтээ Хорлумыг харж болох юм. Гэвч өлсгөлөнгөөр үхсэн өчүүхэн амьтны арьс, яс хоёроор юугаа хийх билээ.!

Фродо өвдөгнийхөө хооронд толгойгоо шургуулж, Сэм гараа дэрлэн хэвтээд юүдэн дороосоо хоосон тэнгэр ширтэв. Тэнгэрт их л удаан юу ч үзэгдэхгүй байснаа дараа нь асар өндөрт нэг шувуу шиг хар юм гарч ирснээ нэг эргэчихээд алга болов. Хоёр дахь, гурав дахь... дөрөв дэх нь гарч ирэв. Тэд дөнгөж үзэгдэх төдий байсан боловч Сэм тэд бол хаанаас ирсэн нь үл мэдэгдэх, луу мэт асар том, урт далавчтай гэж мэдэж байлаа. Тэгээд хурдхан нүдээ аньж, түрүүлгээ харан хэвтэв. Хоромхон зуурт тэрхүү хар морьт, нисдэг мангасын зүрх зүсч, ухаан балайртуулсан хашгирааныг дахин мэдрэв. Гэвч тэр аюул хол байлаа. Хол ч гэсэн бодитой байсан тул Фродо ч түүнийг мэдрэв. Бодол нь үймэрч, цочсон боловч дээш харсангүй.

Хорлум айсан аалз шиг атирав. Далавчит хар сүгнүүд нислэгээ дуусаад Мордор руугаа одлоо. Сэм тайвширч санаа алдав.

- Нөгөө хар морьтнууд дахиад л тэнгэрээр давхилаа. Би харсан. Тэд биднийг тийм их өндрөөс харж чадах болов уу, та юу гэж бодож байна? Түрүүчийн хар морьтууд өдөр сохор юм шиг юу ч үздэггүй байсан биз дээ?

- Тийм л юм шиг байсан, гэхдээ морьд нь юм үздэг байсан. Энэ хар сүгнүүд ямар ч махчин шувуунаас илүү хардаг байж мэднэ. Тэд нэг юм л хайгаад байна. Дайсан их болгоомжилж байгаагийн шинж.

Айдас алга болсон ч анир чимээгүйн хөшиг бас алга болж, тэд үл үзэгдэх арал дээр ил байгаа юм шиг, хөшгийг хуу татсан болохоор одоо тал бүрээс аюул нөмөрч байгаа юм шиг санагдав. Гэвч Фродо Хорлумд хариу хэлсэнгүй, тэр сонголтоо хараахан хийгээгүй байлаа. Нүдээ аньж, дотор хүнтэйгэ зөвлөн зүрхнийхээ зөвлөгөөг хүлээн, ой ухаанаа шүүрдэж байв. Эцэст нь босч ирэхэд нь одоо л шийдвэрээ хэлэх нь дээ гэж бодмоор байлаа. Гэтэл тэгсэнгүй, харин:

- Сонсч байна уу? Энэ юу вэ? – гэж асуув.

Алсад дуулалдах, бүдүүлгээр хашгиралдах бүдэг чимээ гарснаа улам ойртон тодорч байлаа. Хар сүгнүүд биднийг харчихаж, тэгээд тэднээс ч илүү аймшигтай байж мэдэх Сауроны зарц нар бидэн рүү ирж байна гэж хоёулаа зэрэг бодов. Газарт наалдан хэвтээд чагналаа. Нөгөө чимээ бүр ойртон ирж, хоорондоо ярилцах, зэр зэвсэг, тоног хэрэгсэл хангир жингэр дуугарах сонсдов. Фродо, Сэм хоёр илдээ шүүрэв. Зугатах газар байхгүй.

Хорлум хонхрын зах өөд аалз адил мөлхөн гараад, толгойгоо цухуйлгалгүй, чулууны хоорондуур болгоомжтой харж, хөдөлгөөнгүй, чимээгүй дүүжлэгдэв. Дуу чимээ ойртож ирснээ холдон холдсоор чимээгүй боллоо. Моранноны хэрэм дээр бүрээ хангиналаа. Хорлум гүрвэл шиг мөлхөн хүрч ирэв.

- Хүмүүс Мордор руу цувж байна. Хар царайтай хүмүүс. Бид урьд өмнө тийм хүмүүсийг харж байгаагүй. Смеагорл тийм хэрцгий царайтай хүмүүсийг харж байгаагүй. Тэд хар нүдтэй, урт хар үстэй, чихэндээ алтан цагаригтай байна. Тийм ээ, тэд янз бүрийн алт, гоё алт энд тэндээ зүүсэн байна. Хацраа улаанаар будсан, улаан цувтай, дашмаг, жадны үзүүр нь бас улаан. Бамбай нь дугариг, шар, хар өнгөтэй, дундаа том төмбөгөртэй. Муу хүмүүс, харгис хэрцгий гэдэг нь харваас илт байна. Орхуудаас ч муу. Тэд өмнөдөөс, их мөрний цаад үзүүрээс, өмнөд замаар ирсэн гэж Смеагорл бодож байна.

Хар хаалга руу явж байна, араас нь бусад нь ирнэ. Хүмүүс байнга Мордор руу явж байна. Хэзээ нэгэн цагт бүх хүмүүс Мордорт ирнэ, цаана нь үлдэхгүй.

- Олифантууд тэдэнтэй хамт байна уу? - гэж Сэм айдсаа таг мартаад чихээ сортойлгон асуув.

- Үгүй, байгаагүй. Олифантууд гэж хэн юм бэ? – гэж Хорлум асуув.

Сэм босч, нуруугаа үүрээд (тэр “шүлэг ярихаараа” заавал нуруугаа үүрдэг) уншиж эхлэв:

Би хулгана шиг саарал.

Нуруу минь дээврээс өндөр.

Хамар минь могой шиг.

Хөл дор минь газар чичирнэ.

Би өвс идэх дуртай.

Андуураад мод ч унагачихдаг.

Хөлөөрөө топ топ,

Чихээрээ хлоп хлоп,

Хэзээ ч унтаж үзээгүй

Хичнээн мянган жил тэнэсэн,

Амнаас минь эвэр цухуйна.

Алдрыг минь Олифант гэдэг,

Алс өмнөд хязгаарт амьдардаг.

Араатнуудаас хамгийн эртнийх,

Аварга том, айхтар цэцэн.

Хэрэв намайг үзээгүй бол,

Хэзээ ч дахиж хараагүй бол

Хоосон үлгэр гэж намайг хэлнэ.

Харин намайг олифант гэдэг,

Хэзээ ч би унтахгүй.

- За, би Хоббитанидаа байхдаа нэг ийм шүлэг сонссон юм даа. Хоосон үлгэр ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. Манайд ч гэсэн өмнөд хязгаарын тухай өчнөөн үлгэр домог байдаг юм. Эрт цагт аль нэг хоббит гэнэтхэн гэрээсээ гараад харсан зүг рүүгээ аялаад явчихдаг байсан юм. Зарим нь тэр чигтээ явчихдаг, зарим нь эргээд ирэхэд ярьсныг нь үнэмшдэггүй байсан юм. Харин “Уулын суурины мэдээ” гэх нэг хэрэг, “Хоббитанид хэвлэв” гэх нэг хэрэг. Би нарлаг орны хар аваргуудын тухай яриа ч сонссон. Манайхан тэднийг бараанууд гэдэг, тэд олифант унаж байлддаг гэж ярьдаг. Олифантууд нуруун дээрээ байшин, цамхаг тээгээд, мод чулуугаар дүүгүүрддэг гэсэн. Чиний хэлснээр: “Будаг нялж, алт зүүсэн

өмнөдийн хүмүүс”, тэгээд л би: “Олифантууд байсан уу?” гэж асуусан юм. Хэрэв байсан бол би харах гэж харайж гараад, бөндгөр минь өнхрөх байлаа. Гэвч ертөнц дээр тийм араатнууд байдаггүй ч байж болно – гээд Сэм санаа алдав.

- Үгүй ээ, олифантууд байгаагүй. Смеагорл тэдний тухай хэзээ ч сонсч байгаагүй, харахыг ч хүсэхгүй байна. Смеагорл ертөнц дээр тийм араатнууд байхыг хүсэхгүй. Тэр эндээс хурдхан явж, найдвартай нуугдахыг хүсч байна. Смеагорл эзнээ хамт явахыг хүсч байна. Сайн эзэн минь, Смеагорлтой хамт явах уу?

Фродо босов. Тэр хичнээн ихээр санаа зовж байсан ч Сэм эртний хүүхдийн шүлэг уншихад өөрийн эрхгүй инээсэн бөгөөд тэр инээд түүнд шийдвэр гаргахад нь тусалжээ.

- Ээ дээ, бидэнд мянган олифант байсан бол доо, хамгийн цагаан дээр нь Гэндальфыг суулгаад манлайдаа явуулах юмсан, тэгвэл энэ хараалт оронд орж чадах байсан даа. Гэвч бидэнд олифант байхгүй, зөвхөн ядарч сульдсан хөл маань л байна, энэнд маань хамаг найдвар байна. За, Смеагорл, гурав бол азын тоо. Чиний гурав дахь зам хаа байна? Явцгаая.

- Сайн эзэн, ухаантай эзэн, сайхан сэтгэлтэй эзэн! – гэж Хорлум баярлан дуу алдаад, Фродогийн хөлийг тэвэрч: - Хамгийн сайн эзэн! Амарцгаа, сайн санаат хоббитууд минь, харин зэгсэн дор, яагаад ч харагдахааргүй нуугдаарай! Унтаж амарцгаа, Шар хоншоор алга болохоор бид хурдхан явна. Сүүдэр шиг чимээгүйхэн, хурдхан гүйнэ дээ!

Бүлэг 14

Амталж чанасан молтогчин

Фдрийн үлдсэн хагасыг нарны гэрлээс нуугдан амарч өнгөрүүлээд, сүүдэр уртсан, хонхорт бүрэнхий болоход багахан идэж, нэг хоёр балга ус уугаад замдаа гарахаар зэхэв. Хорлум пуглибаас урьдын адил хамраа буруулсан боловч уснаас татгалзсангүй.

- Мөдхөн ханатлаа ууна – гээд тэр уруулаа долоож: - Уулнаас мөрөн рүү их сайн ус урсдаг юм. Бидний замд тааралдана. Тэнд Смеагорл ус ч ууна, идэх юм ч олно. Тэр их өлссөн, маш их, хорлум! – гээд тэр өргөн хавтгай сарвуугаараа хонхор гэдсэн дээрээ дарахад нүд нь ногоон очисоор гялалзав.

Харуй бүрий болох үес тэд хонхрын баруун захад мөлхөж хүрээд, босч, замын далангийн хажуугийн бэлд нь ухааж төнхөчсөн хатуу газраар гүйж эхлэв. Тэргэл сар гартал гурав хоног дутуу боловч эхлээд хав харанхуй байснаа шөнө дунд болохоос өмнө тод сар уулсын цаанаас хөөрөв. Мордорын соёо улаан туяагаараа харанхуйг өрөмдөж, өөр үзэгдэх харагдах юмгүй, сонсогдох чимээ ч үгүй байсан боловч үл зүүрмэглэгч Моранноны нүднүүд тал бүр тийш ширтэж байгаа нь мэдээж билээ. Өрөөсөн нүд шиг улаан туяа чулуурхаг хоосон газраар бүдчин, гүйж яваа гурвын араас харсаар үлдэв. Тэд зам дээр гарахаас болгоомжилж, зүүн талаар нь аль болохоор зайдуу гүйж байлаа. Үүрээс өмнөхөн улаан туяа галт цэг болоод бүрмөсөн алга болох үес тэр гурав замдаа ганцхан удаа түр амарсан учир ихэд ядарсан байлаа. Зам өмнө зүг рүү эргэв.

Хэсэг зуур санаа амарч, амрахаар суусан ч Хорлум өргөсөн дээр суусан юм шиг өндөлзөж байв. Тэр Моранноноос Осгилиатын дэргэдэх замын уулзвар хүрэх гуч орчим бээр газрыг дөрвөн шөнийн дотор туулахаар тооцсон байв. Дахиад л бараг алхам тутамдаа бүдрэн гүйж эхэлсэн боловч удалгүй гэгээ орж, хоосон саарал газар улам ил гаран тодорч эхлэв. Бараг найман бээр газар гүйсэн тул хоббитуудын өвдөг нугарч, цаашид аз сорих хэрэггүй болов.

Тэндхийн газар Мордорын хаалганы ойролцоох газар шиг бүрэн сүйдчихээгүй, арай ч хоосонгүй байлаа. Зүүн талаас уулс урьдын адил хүглийж, ойрхон харагдаж байгаа өмнөдийн зам бүрэнхий бэлээс баруун тийш хазайжээ. Дээд хажуугийн моддын бараан дүрс нам суусан үүл шиг харагдаж, өмнөөс нь мэдэх мэдэхгүй бутнууд ургасан зэлүүд тал цэлийж байлаа. Энд тэнд ганц хоёр нарс харагдана. Зүдэрсэн хоббитуудын сэтгэл бага зэрэг сэргэлээ. Агаар нь цэнгэг, анхилуун тул тэртээх Умард тойргийг нь санагдуулж байв. Айдас цаашилж, Сауроны эзэмшилд саяхан орсон газар учир онгон төрхөө бараг алдаагүй ажээ. Гэвч хоббитууд хар эзний хурц соёот ам ойрхон байгааг мартаагүй байв.

Өдөр нь ядаргаатай урт үргэлжлэв. Тэд буган төгөлд хэвтэж, цагийг яаж ийгээд өнгөрүүлж байлаа. Фродо байн байн унтаж, Сэм хагас дутуу зүүрмэглэж байв. Харин Хорлум байдгаараа хурхиран, дөрвөн мөчөө татагнуулан ухаангүй унтсаар. Ингэж угтсаных нь төлөө толгойг нь авмаар санагдаж уур хүрнэ. Үнэндээ Сэм ганц Хорлумаас ч болоод унтаж чадахгүй байгаа юм биш, өлссөнөөс болжээ. Гэрийн сайхан халуун хоол санаанаас үл гарна.

Эргэн тойрон саарал бүрэнхий буухад тэд замаа хөөлөө. Удалгүй Хорлум зам дээр гарахад тэд хурдаа нэмэв. Хаа нэгтээ туурайн чимээ гарах вий гэж чихээ дэлдийлгэн чагнаж явлаа. Гэвч ямар ч чимээ сонсогдсонгүй, шөнө тайван өнгөрөв.

Энэ зам их эртнийх бөгөөд Мораннонаас гуч орчим бээр газарт шинээр сэргээсэн ба өмнөд хэсэг нь бараг мэдэгдэхээргүй болжээ. Замыг ажлаа мэддэг мастерууд тавьсан бололтой. Тэгшхэн, шулуун бөгөөд хадан бэлийг зүсч, горхинуудын дээгүүрх өргөн нуман хаалгануудын дундуурх гүүрээр гарчээ. Гэвч цаашлах тусам бүдэгрэн үзэгдэхээ больж, өвс, бут битүү ургасан байв. Гэлээ ч гэсэн тэдний хүрэх газарт хамгийн дөт, шугам татсан мэт шулуухан ажээ.

Ийнхүү тэд нэгэн цагт хүмүүс Итил гэж нэрлэдэг байсан ойрхог, горхи булаг олонтой намхан уулст хүрэв. Сар бараг бүтэн болж, одод яралзан, агаар улам л анхилам сайхан болсоор, энэ нь Хорлумд улам л таалагдахгүй байгаа бололтой тургиж, ууртай урхирч явав. Үүрээр тэд өмнөөс тулсан хавцлыг нэвт гарсан урт, гүн хавцалд хүрэв. Баруун хажуу өөд авирч гараад эргэн тойрноо харлаа. Уулс зүүн зүг рүү холдон алсад бараа алдарч байна. Баруун талд утаа нөмөрсөн налуу улам намсан доошилжээ. Хоббитанид байдаггүй модод шилмүүсний анхилам үнэр цацан, өргөн өргөн төглүүд сүглийнэ. Анхилам үнэрт өвс, бут газар сайгүй ургажээ. Хоббитууд Уудам хөндийгөөс өмнө зүг рүү хичнээн олон бээрийг хэмжиж тоололгүй явж өнгөрсөн боловч анх удаагаа л хавар болж байгааг мэдрэв. Хавар энд эргэлтгүй эзэгнэж, энд тэндгүй нялх мод цухуйж, өвс ногоон дундаас цэцэгс өндийн, шувууд хоолой мэдэн жиргэнэ. Гондорын орхигдсон цэцэрлэг Итил хаврын гоёлоороо гайхуулж авай.

Өмнө болон баруун талд Андуины дулаан хөндийнүүд алсалж, зүүн талаас Эфель-Дуатын нуруу хашсан бөгөөд алс өмнөдөөс дулаан салхи дураар нисэн ирж байлаа. Сэмийн барааг нь харах байтугай нэрийг нь сонсоогүй мод, бут, цэцэг, өвс ногоо хаашаа л харна дүүрэн байна. Өтгөн ногоогоор хүрээлэгдсэн цөөрмүүдэд уулсын хүйтэн горхинууд Андуин орох замдаа саатжээ...

Мань оргодлууд замаасаа ногоон төгөл рүү шумбан орж, анхилуун цэцэрлэгт умбав. Хорлум ханиаж, хамраа дарж, алийгаа алдаж байхад хоёр хоббит цээж дүүрэн амьсгалж байв. Сэм гэнэт тачигнатал инээв. Тэр инээдтэй байсан учраас биш, баярласандаа инээжээ. Түргэн ургалт горхи даган жаахан уруудтал эргэн тойрон анхилам цэцэгс, бутаар хүрээлэгдсэн чулуун бассейн байв.

Тэд ханатлаа ууж, угааж, булхаж аваад амрах газар хайлаа. Ямар ч гэсэн дайсны эзэмшлийн газар шүү дээ. Замаас жаахан холдтол цэргийнхний сүйтгэсэн байгалтай тулгарав. Газрын хуучин ба шинэ шарх, орхуудын юм уу, Сауроны бусад хар үйлтнүүдийн хийсэн ажил зөндөө байна. Ялгадасын нүхнүүд өмхий самхайгаар утаж, энд тэндгүй мордор бичигтэй, нүд зурж тэмдэглэсэн моднууд хөглөрч байна.

Сэм мод бут, цэцэг навч, өвс ногоо судалж, ойрхон байгаа Мордорыг мартаж орхижээ. Гэвч Мордор өөрөө түүнд сануулаад өгөв. Сэм Изгарын нүхэнд хариугүй уначих шахжээ. Тэр нүх шатаасан, цавчсан яс, хохимойгоор дүүрэн байв. Сэм яаран буцсан боловч өөрийнхөө энэ нээлтийн талаар үг дурссангүй. Өлсгөлөн хэвээрээ байгаа Хорлум тэр нүх рүү орж, яс мэрэх нь гарцаагүй гэж болжээ.

- Арай илүү тухтай газар олъё, гэхдээ доошоо биш дээшээ. Хэдийчинээ дээш гарвал төдийчинээ сайн – гэж тэр хэлэв.

Үнэхээр ч жижигхэн нуурын дээхнэ талд өнгөрсөн жилийн бутны хар хүрэн өнгөт төгөл байж байлаа. Эргэн тойронд нь хушин ой хүрээлжээ. Тэнд шургаж ороод дулаахан, цэлмэг өдрийг өнгөрөөхөөр шийдэв. Уг нь Италийн ой шугуйгаар яваад л баймаар, тэгээд ч орхууд өдрийн гэрэлд дургүй, гэвч тэд хаа нэгтээ нууц газарт отож байвал яана? Түүнээс гадна Саурон тагнуул хангалттай олон. Тэртэй тэргүй Хорлум тэнгэрт байгаа Шар хоншоортын илчинд тэсэхгүй нь мэдээж билээ.

Сэм хоолны тухай л бодож байлаа. Хараалт хар хаалга руу одоо яараад хэрэггүй, эзнийхээ алсын хараагүй, хэнэггүй занд бас л уур нь хүрч байв. Цаашид юу болохыг хэн ч үл мэднэ, эльфийн аяны талхаа хар өдөрт нөөцлөх хэрэгтэй байдаг. Гурван долоон хоногт хомсхон хооллоход хүрэлцэнэ гэж тооцоолсноос хойш зургаа хоног өнгөрөөд байна.

“Хэрэв хожимдохгүй бол сайн л байна! Дараа нь юугаа идэх вэ, хуруугаа хөхөх юм уу? Дараа нь юу ч болохгүй гэж эзэн хэллүү! Тэгвэл яаж болохгүй вэ?” – гэж Сэм бодож байв. Тэгээд ч шөнөжин гүйсний дараа усанд орж, баахан ус уусан болохоор бүр ч их өлсч байлаа. Исторбинк дээрх хуучин гал тогоондоо иддэг шигээ нэг сайхан халуун хоол идвэл мөн ч хэрэгтэй байна даа гэж бодонгуут гэнэт нэг санаа төрж, Хорлум руу харав. Тэр дөрвөн хөллөөд бутнаас мөлхөн гарахаар ийш тийшээ хамраа сарталзуулан үнэрлэж байв.

- Эй, Хорлум! Хаачих нь вэ? Анд явах нь уу? Хурдан шүүрэгч ээ, чамд хэлэх юм байна. Чи манай хоолонд дургүй, би ч гэсэн залхаж байна. Чи өнөөдөр эзэнд туслах гэж их мэрийж байгаа шүү дээ. Өлөн хоббитуудад идчих юм олоод ирэх юм биш үү?

- Бололгүй яахав, бололгүй яахав. Хэрэв аятайхан гуйх юм бол Смеагорл ямагт тусална.

- Би аятайхан л гуйж байна шүү дээ.

Хорлум алга болов. Фродо хагас путлиб зажилчихаад бутан төгөл рүү лавхан ороод унтаад өглөө. Сэм түүнийг хэрхэн унтаж байгааг харав. Дөнгөж үүр цайж байгаа боловч эзний нүүр болон алдалсан гар нь сайн харагдаж байлаа. Фродо үхлийн шархаа эмчлүүлж Элрондын өргөөнд байхдаа өдөр шөнөгүй унтаад л байсныг тэр гэнэт саналаа. Тэгээд Сэм түүний дэргэдээс бараг холдолгүй ажиглаж байтал эзэн нь дотроосоо гэрэлтээд байгааг анзаарав. Яах аргагүй гэрэлтэж байна. Хэдэн сар биш олон хоног өнгөрсөн юм шиг хөгширсөн Фродогийн царайд ядарсан, санаа зовсон ул мөр ч алга. Царай нь өөрчлөгдөөгүй боловч үй олон нарийхан үрчлээ тодорчээ. Сэм толгойгоо сэгсрээд:

- Юу ч гэхэв дээ. Би хайртай. Тэр угаасаа дотроосоо гэрэлтдэг юм. Юуны чинь хайртай, ингээд гүйцээ! – гэж хэлэхдээ энэ үгнээсээ огт өөр зүйлд санаа зовж эхлэв.

Хорлум чимээгүй эргэж ирэв. Тэр Сэмийн мөрөн дээгүүр Фродо руу харснаа нүдээ аниад нэг ч үг хэлэлгүй мөлхөн холдов. Минутын дараа Сэм түүн дээр очтол зажилж, залгиж байгаа нь сонсдов. Дэргэд нь хоёр молтогчин хэвтэж байх бөгөөд тэр өлөн нүдээр тийшээ харах ажээ.

- Смеагорл ямагт дуулгавартай тусалдаг. Тэр молтогчингууд авчирсан, амттайхан молтогчингууд. Гэвч эзэн унтаж байна. Сэм ч гэсэн унтахыг хүсч байгаа биз дээ? Тэр одоо молтогчин идэхгүй юу? Смеагорл их мэрийсэн боловч араатангууд амархан баригддаггүй юм.

Сэм одоо молтогчин идэхийг зөвшөөрч байсан бөгөөд Хорлумд тэгэж хэллээ. Гэвч түүхийгээр нь идэх гээгүй билээ. Бүх хоббитууд молтогчингоор хоол хийж чадна, бичиг үсэг сурахаасаа өмнө хоол хийж сурдаг, бичиг сураагүй ч хоол хийж сурдаг билээ. Тэр дундаа Сэм гарамгай тогоочийн тоонд ордог, хичнээн ч удаа аялахдаа Сэм л хоол хийдэг байв. Эзэнтэйгээ бэрх холын аянд гарахдаа ч хоолны авсаархан хэрэгслүүдээ хамгийн гол зүйл атга давстай хамт жижиг модон хайрцагт нандигнан хийсэн юм. Гэвч гал түлэх хэрэгтэй байдаг, жаахан ажил орох боловч түлэхээс яахав. Сэм бодосхийгээд, кинжаалаа гаргаж, билүүдээд, эзнийхээ дэргэд суун молтогчингуудыг янзалж эхлэв.

- Хорлум, би чамаас бас нэг юм гуйя, чи энэ хоёр жижиг хувинд ус аваад ирэхгүй юу?

- Хэрэв гуйсан бол Смеагорл ус аваад ирнэ, харин хоббит ийм их усаар яах нь вэ? Усанд орсон, уусан шүү дээ.

- Таахгүй байвал ирээд хараарай. Ус авчирчихаад л мэднэ. Харин хувингуудыг толгойгоороо хариуцна шүү.

Хорлумыг ирэхээс өмнө Сэм Фродогийн царайг дахин харав. Тэр урьдын адил тайван унтаж байсан боловч нүүр, гар хоёр нь ямар их эцэнхий байгааг үзээд онцгой их гайхав.

- Хэтэрхий турсан байна даа, хоббит огт биш юм шиг. За яахав, хоол хийчихээд сэрээе.

Сэм хэсэг хуурай бут, хуш модны олон салаа хуурай мөчир авчирч овооллоо. Тэр уулаар тэмтэрч яваад хэт бэлтгэж, бараг утаагүй, сайхан үнэртэй гал асаав. Хорлум аяга шиг жижигхэн хоёр хувинд дүүрэн ус хийгээд цалгиахгүйн тулд байдгаараа хичээн, амандаа үглэсээр ирэв. Тэр усаа цалгиалгүй тавиад Сэм юу хийж байгааг харангуутаа уурлаж, айсандаа сөөнгөтөн хашгирав:

- Аххх! Үгүйшшш! Болохгүй! Тэнэг хоббитууд галзуурчээ. Тийм ээ, бүрмөсөн галзуурчихаж. Ийм юм хийж болохгүй!

- Юу хийж болохгүй гэж?

- Муухай улаан хэл цоролзуулж болохгүй! Болохгүй, тэр их аюултай. Хаздаг, түлдэг. Тэр биднийг дайсанд барьж өгнө, заавал барьж өгнө!

- Барьж өгөхгүй ээ, хэрэв нойтон, чийгтэй мөчир түлэхгүй л бол барьж өгөхгүй. Бариад өгчихвөл бидний хувь тавилан л биз, тавилангаас хаашаа зайлах вэ. Би эзэнд сайн хоол хийж өгөх хэрэгтэй байна.

- Чанана гэнэ үү! Смеагорлын барьж өгсөн хичнээн сайхан махыг чанана гэнэ ээ, хөөрхий өлгөлөн Смеагорл! Яах гэж? Яах гэж энэ вэ, тэнэг? Энэ чинь жижиг, шүүслэг, амттайхан

молтогчин. Зүгээр ид, май! – гээд тэр урт хумстай сарвуугаа галын дэргэд ногоон дээр байсан мах руу сарвайхад нь:

- Хойшоо бай, савраа тат! Амт, өнгө хоёрт найз байдаггүй юм. Чи бидний хоолноос зугтаадаг, би түүхий мах идэж чадахгүй. Чи надад сайхан хоол барьж өгсөн, би тэрийг яаж идэхээ мэдье. Чамайг тэмэрч үхсэн ч би хоолоо хийнэ. Явж өөр хэдийг л бол хэдийг барьж ид. Харин надад харагдалгүй идээрэй. Яв яв, тэгэхгүй бол хэн хэндээ гай болоод байна, чамд миний гал, надад намгийн өмхий буг. Галыг би хариуцна, утаа гаргахгүй, санаа бүү зов.

Хорлум бутан дундуур гоншгонон мөлхөж одоход Сэм хоолоо хийв.

- Молтогчонгоор хоол хийхэд хоббитод юу хэрэгтэй вэ? Матлагч ногоо, үндэс, талх мэдээж хэрэг. Өвс ногоо ч дэргэд байна - хэмээн өөртөө ярьж байснаа: - Хорлум! Найзын ёсоор гурав дахь удаагаа тусалчих. Надад хэдэн ногоо зулгааж өгөөч.

Хорлум бутан дотроос толгойгоо цухуйлгасан боловч тэрний нүүрэнд найзын ч, тус болохын ч шинж тэмдэг алга.

- Лаврын навч, гоньд, мангир, түргэлээрэй, ус буцлахаас өмнө - гэж Сэм хэлэв.

- Үгүй ээ! Смеагорл ууртай. Смеагорл өмхий өвснүүдэд дургүй. Тэр элдэв өвс, үндэс иддэггүй, үгүй ээ, миний эрдэнэ минь, зөвхөн бүрмөсөн өлсөхөөрөө юм уу, өвдөхөөрөө л, хөөрхий муу Смеагорл.

- Хэрэв хөөрхий муу Смеагорл үгэнд орохгүй бол одоо ус буцална, тэгээд түүнийг хүчтэй хазна, ууртай Сэм түүний хамар руу халуун ус цацна, тиймээ миний эрдэнэ минь. Намар байсан бол чи надад зэрлэг лууван, төмс, манжин малтаж авчрах байсан юм. Энд өөр олон сайхан ургамал ургадаг байж таарна. Тавхан ширхэг төмс байдаг ч болоосой!

- Смеагорл хаашаа ч явахгүй, тэр яваад олоод ирсэн, эрдэнэ минь, тэр их ядарсан, тэр явахаас айж байна, муухай зантай, өөдгүй хоббит. Смеагорл газар малтаж, төмс, лууван, үндэс хайхгүй. Ямар төмс вэ эрдэнэ минь, төмс гэж ямар юм байдаг юм бэ?

- Бө-өө-рөн-хий, Жихар төмсөнд ухаангүй дуртай, хоосон ходоодоо төмсөөр дүүргэчихвэл ертөнцөд түүнээс сайхан юм үгүй. Чи төмс хайх хэрэггүй, тэртэй тэргүй олохгүй. Харин чи дуулгавартайхан Смеагорл болоод хэдэн өвс тастаад ир. Тэгээд л эвлэрье. Хэрэв чиний буруугаар муудалцахгүй бол би чамд төмстэй хоол хийж өгнө. Жигнэсэн загас, шарсан төмс хоёр ч Сэм Скрэмбийн брэнд дээ. Татгалзахгүй биз дээ.

- Үгүй, үгүй, татгалзаж байна. Амттайхан загасыг жигнэж, шарж болохгүй. Загасаа одоо өгчих, муухай төмсөр яах юм бэ!

- За за, чамтай ярина гэдэг вандуйгаар ходоодоо дүүргэсэнтэй адил. Явж хурхир!

Сэм эзнээсээ нүд салгалгүйгээр бараг дэргэдээсээ хэдэн навч, үндэс авчрав. Галын дэргэд сууж, ганц нэг мөчир нэмэнгээ санаандаа орсон болгоныг бодож суув. Ус жаахан удаан

буцалжээ. Эргэн тойронд өглөөний туяа тусч, хором хоромоор дулааран, шүүдэр шингэрч эхэллээ. Хувинд молтогчингийн мах буцалж, Сэм тайван ширтэж суугаад эгээтэй л унтчихсангүй. Молтогчингийн махыг шалз чанахад нэг цаг орчим орох тул тэр байн сэрээгээр хатгаж үзэн, шөлөө амсч байв.

Эцэст нь хоол бэлэн болж, тогооч хоолоо гал дээрээс гаргаад Фродог сэрээв. Цаадах нь нүдээ хагас нээж, энэ газрын биш хачин энхрий, уянгалаг зүүднээсээ салав.

- Сэм, чи яагаа вэ? Яагаад унтахгүй байгаа юм бэ? Ямар нэг юм болоо юу? Хэдэн цаг болж байна? – гэж тэр баахан асуулт давхцуулав.

- Үүр цайгаад хоёр цаг орчим болсон. Хоббитанид бол найм хагас орчим болж байгаа. Одоогоор юу ч тохиолдоогүй. Гэхдээ сонгино ч байхгүй, төмс ч байхгүй. Би жаахан хоол хийчихлээ, шөл ч байна, жаахан тэнхэрч ав. Аягалах уу? Шууд тогооноос нь идсэн ч болно. Жаахан хөрөг.

Фродо эвшээж, суняв.

- Чи унтаж амар, Сэм, энд гал түлэх ч хэрэггүй байсан юм. Гэхдээ би аймаар өлсч байна. Хмм! – хэмээн үнэртсэнээ: - Бүр эндээс үнэртэж байна. Чи ямар гээч хоол хийчих вэ?

- Смеагорл өгөөмөр загнасан юм аа. Бидэнд хоёр молтогчин барьж өгсөн, одоо харамсч байгаа биз. Гэхдээ хачир байхгүй, амтлах юм харин олдсон шүү.

Тэр хоёр тухтайхан сууж аваад, жижигхэн тогоонцортой хоолоо өмнөө тавьж, хуруун чинээ халбага, сэрээгээр халбагадаж, сэрээдэн хооллов. Нэг путлиб хувааж идлээ. Нэг үгээр хэлэхэд сайхан найрлав.

- Хорлум! Нааш ир, оройтоогүй дээр бодлоо өөрчилж үз. Шаз чанасан молтогчин амсч үз, зөндөө үлдлээ – гэж Сэм дуудав.

Гэвч таг чимээгүй.

- Одоо яахав, идэж дуусгахаас. Тэр өөрийгөө гомдоохгүй, ангийн шинэ махны эрэлд гарсан гэж бодож байна – гээд Сэм санаа алдав.

- Одоо явж унт - гэж Фродо хэлэв.

- Би ч жаахан унтана аа, харин эзэн минь та битгий зүүрмэглэчихээрэй. Сэрэмжтэй байх хэрэгтэй шүү. Тэрний тэн хагас нь өмхий хэвээрээ байгаа. Эхлээд тэр намайг багалзуурдах гэж оролдох вий. Тэр бид хоёр түнжин муутай. Түүнд Сэм таалагдахгүй байна, үгүйшшш, эрдэнэ минь, огтооссс таалагдахгүй байна хэмээн тэр сүүлчийнхээ өгүүлбэрээ Смеагорлыг дуурайн шүдэн завсраараа сийгүүлэн хэлэв.

Тэр хоёр тогоонцроо долоогоод, Сэм горхин дээр очиж, савнуудаа угаав. Нар утаан үүл, манан дээгүүр мандаж, ойг алтлаг туяагаараа гийгүүллээ. Яг тэдний байгаа төглийн дээгүүр нарны гэрэлд ажиглагдахгүй байх аргагүй нарийхан саарал утаа харагдав. Сэм галаа сайн

унтраагаагүй ажээ.

- Ээ хөөрхий, юу ч гэхэв дээ! Ээ зулбасга! – гэж тэр амандаа үглээд ухасхийн буцаж гүйснээ зогтусан чагнав. Хэн нэгэн исгэрэх шиг, тэгэж санагдав уу? Эндхийн ямар нэг шувуу юм болов уу? Исгэрсэн бол Фродогийн байгаа газраас л лав биш. Нөгөө талаас хариу исгэрэх сонсогдлоо. Сэм хар хурдаараа гүйлээ.

Галын дэргэдэх бут руу оч үсэрч, хатсан өвсөнд гал авалцсан байлаа. Сэм үүсч буй галыг дэвсэн унтраагаад, галын цогийг дэвслэн бүрэн унтраж, үнсийг нь тарааж цацав. Тэгээд Фродо руу мөлхөж очлоо.

- Исгэрэх, хариу исгэрэх дуу сонсов уу? Нэг хоёр минутын дараа л хүрээд ирнэ. Доош буцах уу? Шувуу байсан бол сайн л биз, шувуу гэхэд нэг л биш байсан даа. Шувууны дуугаар харилцан дохио өгч байх шиг байна. Дээр нь бас галаас утаа гарчихаж! Надаас болж гай дэгдэх нь байна, хэрэв бид хоёрыг тэр дор нь эд бад хийчихгүй бол би хэзээ ч энэ алдаагаа уучлахгүй!

- Чшшш! Хүмүүс ярилцах шиг – гэж Фродо шивнэв.

Хоббитууд хоромхон зуурт үүргээ эмхлэн үүрээд, төгөл рүү холхон мөлхөж оров. Одоо хүмүүс ярьж байгаа нь эргэлзээгүй болсон бөгөөд аяархан, болгоомжтой ярилцаж байгаа боловч улам бүр ойртсоор байлаа. Гэнэт хэн нэгэн улаан дэргэд нь:

- Энд галын ул мөр байна. Энэ хавиас л утаа гарч байсан шүү дээ! Тэр хол зугтааж чадахгүй. Энэ төгөлд л нуугдсан байх ёстой. Одоо бид түүнийг молтогчин шиг барьж аваад ямар гээч шувуу болохыг нь мэдэж авна аа! – гэхэд:

- Тэгээд мэдэж байгаа бүхнийг нь хэлүүлнэ! – гэж өөр нэг нь хэлэв. Төгөлд дөрвөн хүн тал талаас орж ирлээ. Зугтаах газаргүй, нуугдах оройтсон, Фродо, Сэм хоёр босон харайж, илдээ сугалаад нуруугаа нийлүүлэн зогсов.

Гэвч анчид ангаасаа илүү мэл гайхсан байлаа. Чилгэр өндөр дөрвөн дайчин газарт хадаастай мэт нам зогсов. Хоёр нь гэрэлтэй өргөн үзүүр бүхий жад барьжээ. Нөгөө хоёр нь хүний өндрийн дайтай нум, урт ногоон өдтэй сум агсчээ. Бүгдээрээ урт илд зүүсэн байв. Хүрэн ногоон толботой хувцас нь өнгөлөн далдлалтынх бололтой, ногоон ханцуй, ногоон юүдэнтэй, нүүрэндээ багтай ажээ. Зөвхөн хурц, тунгалаг нүд нь л харагдаж байв.

Фродод нэг нь яг л Боромир харагдав. Энэ хүмүүс Боромиртой нуруугаараа, байгаа байдлаараа, хэлээрээ ч адилхан байлаа.

- Эрсэн этгээдээ олсонгүй, харин оронд нь хэнийг олчихов? – гэж нэг нь асуулаа.

- Эд нар орхууд биш байна гэж нөгөө нь хэлээд илдээ буулгав. Фродо Терн илдээ сугалахад тэр бас илдээ нүцгэлсэн ажээ.

- Эльфүүд юм болов уу? – гэж гурав дахь нь итгэлгүйхэн дуугарав.

- Үгүй ээ! Эд эльфүүд биш – гэж тэдний хамгийн өндөр бөгөөд байдлаас харахад удирдагч нь бололтой хүн хэлээд:

- Эльфүүд Итилд орж ирэхээ больсон. Тэгээд ч эльфүүд чинь гайхамшигтай гоо сайхан ардууд шүү дээ.

- Бид хоёр та нарыг гоо сайхнаараа гайхуулж чадсангүй бололтой. Сайхан үг хэлсэнд баярлалаа. Ингэхэд та нар бид хоёрыг хэн бэ гэж маргахаа болиод өөрсдийгөө танилцуулж, хоёр муу ядарсан аянчийн амралтыг ямар учраас бусниулснаа тайлбарлавал яасан юм бэ? – гэж Сэм өгүүлэв.

Ногоон өмсгөлтэй өндөр дайчин тачигнатал инээв:

- Би бол Гондорын цэргийн жанжин Фарамир, энэ хязгаарт аянчид явдаггүй юм. Тэгэхээр та нар нэг бол хар хүчинд, эсвэл гэгээн хүчинд үйлчилдэг байж таарна.

- Гэхдээ аль нь ч биш ээ гээд Фродо Фарамир жанжинд зохих бүх хүндэтгэлийг үзүүлсний дараа - Бид ердөө л аянчид гэсэнд

- Тэгвэл та нар хэн юм бэ, хаашаа зорьж яваа юм бэ, нэн даруй хэл. Бидэнд оньсого таах юм уу, харилцан хүндэтгэл үзүүлэх зав алга. Бас танай гурав дахь дагуул чинь хэн юм бэ, одоо хаана байна? – гэж Фарамир ширүүлэв.

- Гурав дахь аа?

- Тийм ээ, нэг тийм муугүй хулгайч маягийн этгээд. Тэр тэнд цөөрөмд хамраа норгож байсан юм. Тун ч новшийн муухай төрхтэй этгээд. Орх тагнуулуудын нэг юм уу, тэдний гар хөл нь байхаас гарцаагүй. Гэвч тэр ямар нэг хачирхалтай тохиолдлоор биднээс мултарч дөнгөсөн юм.

- Хаана байгааг нь мэдэхгүй, тэр бол бид хоёрын санамсаргүй тохиолдлын дагуул. Би бусдыг нь мэдэхгүй. Гэвч тэр та нартай тааралдвал тэрнийг өршөөгөөрэй, бидэнд хүргэж ирэх юм уу, бидэн рүү явуулчихаарай. Мартагдаж орхигдсон хөөрхийлэлтэй амьтан. Намайг тэрэнтэй хувь заяа холбосон юм. Бидний тухайд гэвэл олон гол мөрний цаадах баруун хойт хязгаар – Хоббитани нутгийн хоббитууд. Намайг Дрогогийн хүү Фродо гэдэг, энэ бол Хэмбриджийн хүү Сэм, би аяндаа дагуулж гарсан хүндэт хоббит. Бид холын Уудам хөндий буюу Имладрисаас ирсэн – гэхэд Фарамир цочих шиг болж маш анхааралтай сонсч эхлэв. Бид долуулаа замд гарсан юм. Нэг нь Мориид амь үрэгдсэн, бусдаас нь бид Рэросын цаадах Парт-Галенд салсан, тэдний хоёр нь манай удмынх, өөр нэг эльф, нэг нь гном, хоёр нь хүн. Арагорн болон өмнөдийн Минас-Тирит хотын Боромир.

- Боромир! – гэж дөрвүүлээ зэрэг дуу алдацгаав.

- Эзэн захирагч Денэторын хүү Боромир уу? – гэж асуухдаа Фарамирын царай хачин ширүүн болов:

- Та нар түүнтэй хамт явж байсан юм уу? Хэрэв үнэн бол энэ чинь ёстой жинхэнэ мэдээ байна шүү. Денаторын хүү Боромир бол Цагаан цайзын дээд хамгаалагч, манай жанжин байсан юм. Бид түүнгүйгээр хэцүүдэж байна. Та нар яагаад түүнтэй нэг баг болсон юм бэ? Түргэн хариул, нар бүр өндөрт хөөрчихлөө!

- Боромир уудам хөндий рүү ямар үгийн нууцыг тайлахаар гарсныг чи мэдэж байна уу? - гэж Фродо асуултаар хариулав.

Исилдурын хугарсан илдийг

Имладрист дахиад давтана...

- Энэ үгийг би мэднэ - гэж Фарамир ихэд гайхан хариулаад:

- Энэ үгийг та нар мэдэж байгаа чинь та нарт сайн хэрэг.

- Тэгэхлээр миний сая дурдсан Арагорн бол тэрхүү хугарсан илдийн эзэн, бид бол жижиг биетүүд, тэнд бидний тухай ч үг байгаа.

- Харж байна аа, - хэмээн Фарамир бодлогошронгуй хэлээд:

- Үнэндээ тийм байж болох зүйлийг л харж байна. Исилдур агуу тулалдааны үеэр олсон хараалт шид гэдэг нь юу юм бэ?

- Энэ одоохондоо нууц, цаг нь болохоор тайлагдана биз дээ.

- Та хоёрыг олигтойхон байцаах хэрэгтэй болох нь дээ, тэгэхгүй бол та хоёр ямар учраас дорно газарт ийм хол явж ирээд, сүүдэрт төөрч яваа чинь ойлгомжгүй байна... – гээд тэр гараараа заасан боловч нэрийг нь хэлсэнгүй: - Гэвч энэ бүхнийг дараа больё, одоо бидэнд зав алга. Та нар энэ замаар юм уу, ойролцоо газраар явсан бол хол явахгүй байсан юм. Үхэл нүүрлэх байсан юм. Өнөөдөр энд их тулалдаан болно, бид нэг бол энэ байлдаанаас амьд гарахгүй, нэг бол дайсныг дараад Андуин руу хурдан ухарна. Би та нарт хоёр дайчнаа үлдээлээ, та нарыг хамгаалахаас гадна миний санаа тайван байх болно. Энэ зам дээр тохиолдлын аянчинд итгэх нь ухаангүй хэрэг. Хэрэв би эргэж ирвэл дэлгэрэнгүй ярилцъя.

- Баяртай! – хэмээн Фродо гүнээ мэхийж: - Миний тухай өөрийнхөөрөө л бод, гэвч би нийтийн дайсны эсрэг тэмцэж байгаа хэн бүхний найз. Та нар шиг хүчирхэг эрэлхэг дайчид бидний тусламжийг голохгүй, би өөрийнхөө даалгаврыг хэрэгсэхгүй байхсан бол бид тулалдаанд хамт ормоор л байна. Та нарын илдэнд ялалтын туяа гийх болтугай!

- Ямар ч байсан жижиг биетүүд ухаалаг ардууд юм байна - гээд Фарамир – мушилзаж: - Баяртай – гэв.

Хоббитууд дахин сууж авсан боловч саяны уулзалтаас төрсөн бодол болон эргэлзээгээ хуваалцсангүй. Дэргэд нь, модны сүүдэрт хоёр хамгаалагч сууж байлаа. Их халуун байсан тул тэр хоёр байн байн нүүрний багаа авч байв. Цайвар арьстай, бараан үстэй, саарал нүдтэй, хүндлэл төрүүлэм сүрлэг, ширүүхэн гунигт царайтай дайчид байв. Тэр хоёр аяархан ярилцаж

байсан бөгөөд эхлээд нийтийн хэлээр боловч нэлээд хуучны аялгаар ярьж байснаа дараа нь өөр хэлээр ярилцав. Фродо эльф хэл сонсоод чихэндээ итгэсэнгүй, бага зэрэг өөрчлөгдсөн ч яах аргагүй эльф хэл байсан тул дайчид руу гайхан харж байв.

Эцэст нь тэр тэдэнтэй ярилцахаар шийдэхэд тэд эхлээд удаан, ганц нэг үгээр хариулж байлаа. Тэднийг Маблунг, Дамрол гэдэг, Гондорын дайчид, Итилийн мөрчид байлаа. Тэдний өвөг дээдэс Итилд амьдардаг байжээ. Эзэн захирагч Денэтор ийм дайчдаар тэргүүн отрядуудаа бүрдүүлсэн ба эдгээр отрядын мөрч дайчид Андуиныг нууцаар гаталж (хаагуур, яаж гаталдгаа яалаа гэж хэлэх билээ) Их мөрөн, Эфель-Дуатын хоорондуур орж ирсэн орхууд болон Сауроны бусад элдэв хүчийг бутниргэдэг ажээ.

- Эндээс Андуины зүүн эрэг хүртэл арав орчим бээр, тийм хол бид цөөхөн гардаг, гэхдээ одоо онцгой тохиолдол. Хородримчүүдийг отоож байгаа юм, тэд ч ёстой зуу дахин хараал идмэрүүд байгаа юм! – гэж Маблунг хэлэв.

- Тийм ээ, өмнөдийн тэр хараал идмэрүүд хэцүү! Эрт цагт Гондор хородримийнхэнтэй худалдаа хийдэг байсан гэж ярьдаг, гэхдээ хэзээ ч найрамдалтай байгаагүй. Эрт цагт Гондорын эзэмшил нутаг Андуины салаанууд хүртэл үргэлжилж байсан гэдэг юм. Хамгийн ойрхоны улс Умбар нь завсрын бүс байсан. Гэхдээ энэ бол их эрт цаг л даа. Тэр цагаас хойш их ус урссан. Умбар задарч, бусад улсынх нь талаар олон жил ямар ч мэдээгүй байсан. Дайсан тэдгээрийн толгойлогчдыг бэлэг сэлт, эрх мэдлээр цаламдаж авсныг саяхнаас л мэдсэн юм. Минас-Тиритийн цайзын насны тоо хэмжээтэй болж байх шиг байна даа. Дайсны хүч даанч их, тэрний хорсол занал хязгааргүй – гэж Дамрод яриу.

- Гэхдээ бид гар хумхиж суугаагүй, тэрний хорт санаанд чадлын хэрээр саад хийж байна - гэж Маблунг яриаг үргэлжлүүлэв:

- Хар цайзын эзэн Мордорын хэрэмний цаана тэртэй тэргүй хэмжээлшгүй их хүч хураачихаад байхад хараал идсэн өмнөдийн тэднээр л дутах юм шиг Мордор руу цувж байна, тэд эрт цагт Гондорын мастеруудын тавьсан эртний замаар цувж байгаа юм. Айж ичих ч юмгүй, ил тод цуваад л. Шинэ эзнийхээ хязгааргүй их хүчинд найдаж байгаа юм байх даа, зөвхөн түүний сүүдэр л биднийг хангалттай хамгаална гэж бодоод байгаа юм. Тэгэж л байг, бид та нарыг бага сага сургаад өгнө өө. Тэдний цэрэг ойртож яваа, тэргүүн отрядууд нь өнөөдөр үдээс өмнө энүүхэн дээр, их зам өнгөрдөг нуранги дээр ирнэ гэж хэд хоногийн өмнө манай тагнуулчид мэдээлсэн юм. Их зам өнгөрдгөөрөө өнгөрнө, харин дайсан өнгөрөхгүй. Фарамир тэднийг өнгөрүүлэхгүй, тэр одоо бидний жанжин. Түүнийг үхэл дайрахгүй, хувь заяа ч хамгаална.

Яриа тасалдаж, тэд чимээгүй суун чагнаж байв. Нэг л хачин нам гүм болов. Сэм нуугдсан бутан дотроосоо харахад эргэн тойронд хүмүүс нэмэгдэн ирж, ганц нэгээрээ юм уу, урт цуваагаараа уулын хажуу өөд мөлхөн өгсч, ой, бутан төгөлд нуугдаж байгаа нь хоббитын хурц нүдэнд үзэгдэж байв. Тэднийг өнгөлөн далдлах хувцас нь найдвартай хамгаалж байгаа нь илэрхий. Бүгдээрээ Фарамир болон түүний хамтрагчидтай ижил хувцас, зэвсэгтэй ажээ. Гэгээн цагаан өдрөөр хажуугаар нь өнгөрөөд оргүй алга болж байв. Бага үдийн нар өндөрт хөөрчээ. Сүүдэр богиносгов.

“Манай нөгөө новшийн идэштг Хорлум хаана яваа юм бол доо? Орх гэж андуураад юу ч үлдэхгүй болгочих вий дээ. Дээрээс нь бас Шар хоншоор шарж байгаа даа. Тэр ч амьд үлдэж чадах л бий вий” - гэж Сэм, нарнаас хамгаалж бут руу гүн шургах зуураа бодов. Тэр Фродогийн дэргэд хэвтгээд зүүрмэглэж байснаа алсад бүрээ дуугарах чимээгээр сэрэв. Сэрээд, өндийж эргэн тойрноо харлаа. Нар хайр найргүй шарж, хамгаалагчид модны сүүдэрт сонор соргог сууж харагдана. Уулан дээр бүрээнүүд чангаар нүргэлэн, байлдааны уриа, зэрлэг хашгиралдаан нэлээн алс, ямар нэг агуйгаас юм шиг сонсогдлоо. Дараа нь тулалдааны нүргээн улам ойртож, хажууханд ирэв. Ган төмөр ган төмөртэйгөө харшилдаж, илд төмөр дуулганд ханхийн бууж, бамбайнд бөглүүхэн тасхийн, орилоон хашгираан холилдон, Гондор! Гондор! – гэсэн чанга уриа цууриална.

- Зуу зуун дархан зэрэг ажиллаж байгаа юм шиг, хэтэрхий битгий ойртоосой доо - гэж Сэм Фродод хэлэв.

Гэвч тулалдаан улам ойртсоор байлаа.

- Гараад ирлээ! Хараач! Хориод өмнөдийнхөн бүслэлтийг сэтэлчихэж: замаас доошоо гүйж байна. Хөлийн хурдаар зугтаж байна. Манайхан гүйцээд ирлээ, Фарамир манлайд нь явж байна!- гэж Дамрод хашгирав.

Сэм тулаан үзэх боломжийг алдахыг хүссэнгүй, хамгаалагчдын дэргэд ирээд харвал улаан хувцастай, бараан царайт хүмүүс налуу руу байдаг хурдаараа гүйж, тэдний араас ногоон хувцаст дайчид гүйцэн ирж, гүйдэл дундаа цавчиж байв. Сум үүл мэт нисэлдэнэ. Гэнэт тэдний дээрх толгой дээрээс нэг хүн модны мөчир хугачин унаж, Фродог эгээтэй л дарчихсангүй. Алтан мөрөвчнийх нь дороос ногоон өдөт сум ёрдойж, улаан цув нь урагдаж, зэс хуяг нь тас цавчигдсан, алтан утсаар сүлжсэн хар гээг нь цусанд будагдсан байлаа. Хүрэн гар нь хугархай илдний бариул атгажээ.

Тийнхүү Сэм хүмүүс хоорондоо яаж аймшигтайгаар алалддагийг үзсэн бөгөөд түүнд огт таалагдсангүй. Амьгүй нүүрийг нь хараагүйдээ тэр баяртай байв. “Хэн гэдэг юм бол, ямар ургийнх юм бол, хорон муухай, харгис хэрцгий нэгэн байсан болов уу, муу санаатанд хууртагдаж, харийн хязгаарт амиа алдсан юм болов уу. Байлдахыг огт хүсээгүй, гэртээ байсан нь дээр байсан юм болов уу, мэдэхсэн” гэж тэр бодлоо.

Гэвч Маблунг алагдсан дайсан руу дөнгөж алхтал ер бусын их нүргээн гарч, орилж, бархирч, бүрээ хангинаж, дараа нь аварга том моднууд унаж байгаа юм шиг хүнд чимээнд газар доргиход энэ бүх бодол нь оргүй алга болов.

- Болгоомжтой! Болгоомжтой! Биднийг хамгаалаарай! Мумак! Мумак! – хэмээн Дамрод хашгирав. Замдаа тааралдсан модыг хуга хуга татан харайж яваа амьтныг Сэм гайхсан, айсан, биширсэн нүдээр харав. Байшин шиг, үгүй ээ, юун байшин, саарал арьстай уул шиг нүсэр аварга амьтан байлаа. Айсандаа нүд нь томорч, амаа ангайсан хородын мумак үнэхээр үзэгдэж харагдаагүй аварга том амьтан ажээ. Тэр шууд тэдэн рүү хурдалж ирснээ хэдхэн алхмын цаагуур өнгөрөв. Хөл нь яг аварга мод шиг, чих нь дарвуул шиг дэрвэж, үсрэх гэж байгаа аварга могой шиг урт хушуугаа өргөсөн, алтан бөгжтэй эвэр шиг соёоны цаанаас хөөсөрсөн цус садарч байлаа.

Алтан чимэгтэй улаан тохош араас нь чирэгдэж, нуруунд нь байлдааны цамхгийн үлдэгдэл шигдэж, асар том бараан дайчин хүзүүнээс нь зүүгдсэн нь өчүүхэн жижиг тоглоом шиг харагдана.

Сэм тэр амьтныг бахдан биширч, урт амьсгаа авав.

- Олифант! Олифантууд байдаг юм байна, би нэгийг нь харлаа. Энэ ч харин амьдрал мөн байна шүү! Гэвч гэртээ хариад ярихаар хэн надад итгэх юм бэ? Хэрэв дахиад өөр үзүүлэх юм байхгүй бол би явж унтлаа.

- Энд унт, одоохондоо болно, гэвч удахгүй жанжин маань ирнэ, мэдээж амьд байгаа бол. Ирмэгц нь бид замд гарна. Дайсан энэ байлдааны тухай сонсонгуут бидний араас цэргээ илгээнэ.

- За явцгаа, явцгаа, харин битгий их нижигнээрэй! Миний нойрыг сэргээчихэв, би бүтэн шөнө унтаагүй – гэж Сэм хэлэв.

Маблунг инээж:

- Фарамир таныг энд үлдээнэ гэдэгт эргэлзэж байна, ноён Сэммиум, гэвч өөрөө мэднэ биз дээ.

Бүлэг 15

Жаргах нарны цонх

Сэм хэдхэн минут унтсан юм шиг санагдав. Гэтэл тэр гурван цагийн дараа, Фарамир болон түүнтэй хамт олон олон дайчид эргэж ирэхэд л сэржээ. Тулалдаанаас амьд үлдсэн бүх дайчид хоёр, гурван зуун хүн уулын хажууд цугларсан байлаа. Тэд том хагас тойрог болон сууж, голд нь Фарамир суусан байх бөгөөд түүний өмнө Фродо зогсчээ. Энэ нь хачирхалтай шүүх хурал мэт харагдана.

Сэм бутнаас мөлхөн гарч ирээд хэнд ч анзаарагдалгүй хагас саран хэлбэрт тал хүрээний нэг үзүүрт очиж суув. Тэндээс сайн сонсогдож, харагдаж байсан учир тэр нүд цавчилгүй харж, нэг ч үг алгасалгүй сонсч байв. Шаардлага гарвал тэр ганцхан ухасхийгээд эзэндээ хүрч болохоор байлаа. Фарамир нүүрний багаа тайлсан байх бөгөөд сүрлэг, захирангуй царай нь ил, хөх саарал нүд нь Фродо руу хурц, нэвт шувт мөртөө бодлогошронгуй ширтэж байлаа.

Фродо нэг юм нууж, хагас дугуу яриад байгаа нь Фарамирт сэжигтэй санагдсан учир ямар учраас Уудам хөндийн орноос отряд дагуулж гарсан, яагаад Боромироос салсан, одоо хаашаа явж байгаа нь түүнд тодорхойгүй байгааг Сэм төдөлгүй ойлгов. Тэрбээр Исилдурын олсон хараалт шидийн тухай байн байн дурсаад байгаа нь хамгийн чухал зүйлийг Фродо нууж байгааг гадарласны шинж байв.

- Хэрэв Исилдурын хараалт шидийг жижигт биет хадгалахаар зориглосон бол, тэр жижиг биет нь чи юм бол тэр хараалт шид гэдэг юу вэ гэдгийг чи мэдэж байгаа, чи түүнийг Зөвлөлд гаргаж үзүүлсэн, Боромир түүнийг харсан. Тийм үү, үгүй юу?

Фродо дуугарсангүй.

- Тийм юм байж! Нууж байна. Гэвч Боромиртой холбоотой бүхэн надад хамаатай. Домогт өгүүлснээр бол, Исилдур орхын суманд оногдсон, гэвч орхын сум тэнд голын ёроолын элсэн ширхэг шиг олон, тэгвэл Гондорын дайчин Боромир тэр олон сумны нэгийг нөгөөх хараалт шид гэж хүлээн зөвшөөрөх гэж үү? Чи түүнийг хадгалдаг байсан юм уу? Тэрнийг нуучихсан гэж чи хэлсэн, чи өөрөө нуусан юм биш биз?

- Үгүй ээ, би нуугаагүй, тэр надад хамаарахгүй, түүнийг эзэмшигч нь агуу ч бай, өчүүхэн ч бай үхэлт амьтдын дотор байхгүй. Хэрэв түүнийг хэн нэгэн эзэмших ёстой бол тэр нь Мориугоос Рэрос хүртэл манай багийг удирдаж явсан Араторны хүү Арагорн, би түүний тухай ярьсан.

- Яагаад Элендилийн хөвгүүдийн өөрсдөө босгосон цайзын хамгаалагч Боромир биш, Арагорн байдаг билээ?

- Яагаад гэвэл Арагорн эцгийн талаасаа Элендилийн хүү Исилдурын шууд удам. Тэр Элендилийн илдийг зүүж яваа.

Үүнийг сонсоод хуралдагсад гайхан дүнгэнэлдэв.

- Элендилийн илд! Элендилийн илд мөдхөн Минас-Тиритэд гялалзах нь! Сайхан мэдээ! – хэмээлдэх нь сонсдов.

Гэвч Фарамир хөмсгөө ч хөдөлгөсөнгүй.

- Магадгүй л юм, гэвч ийм агуу зүйлд баталгаа нотолгоо хэрэгтэй, хэрэв тэр Арагорн Минас-Тиритэд ирвэл түүнээс маргаангүй нотолгоо шаардана. Одоохондоо гэвэл, би зургаа хоногийн өмнө тэнд очиход танай отрядаас тэр ч байгаагүй, өөр хэн нэг нь ч байгаагүй.

- Боромир тэр зүйлийг хүлээн зөвшөөрсөн, энд Боромир байгаасан бол тэр чиний бүх асуултанд хариулах байсан. Бид аль эрт Рэрост салсан, тэр нийслэл рүүгээ шууд явсан юм. Чи одоо очоод бүгдийг мэднэ биз дээ. тэр отрядын бусад гишүүний адилаар ямар учраас Имладрисын эзэн Элронд энэ тухай Зөвлөлд мэдэгдсэнийг мэдэж байгаа. Надад даалгавар өгсөн, тэр даалгаврыг би биелүүлэхээр явж байна, гэвч би үүнээс илүүг хэнд ч хэлэх эрхгүй. Нэг л юм хэлэхэд Дайсантай амиа өрөн тулалдаж байгаа хэн ч гэсэн намайг саатуулах нь Дайсанд тусалж байгаа хэрэг.

Фродо итгэл бардам ярьж байсан ч нуруун дээгүүр нь шоргоолж гүйх шиг болж байсан бөгөөд Сэм дотроо түүнийг бахархан дэмжиж байв. Гэвч Фарамир шургуу шаардсаар байв.

- Тийм байдаг байж! Чи надад бусдын хэрэгт бүү саад бол, бушуухан дуртай зүг рүү явуул, Боромир ирээд бүгдийг тайлбарлаж өгнө гэж зөвлөж байх шив дээ. Түүнийг ирнэ гэж хэлж байна уу, чи! Чи Боромирын найз байсан уу?

Боромир өөр рүү нь яаж довтолж байсныг санаад Фродо тэр даруй хариулсангүй. Фарамирын харц ширүүсэв.

- Би Боромиртой мөр зэрэгцэн олон аюул, хүнд бэрх, зовлон гачаалыг хамт туулсан. Тийм ээ, би түүний найз байсан.

Фарамир зэвүүтэй мушийв.

- Боромир амь үрэгдсэнийг сонсоход чамд хэцүү байсан юм биз дээ?

- Мэдээж, - гэж Фродо гайхан хариулснаа Фарамирын нүд рүү хараад мэгдэж: - Амь үрэгдсэн гэв үү? Тэр амь үрэгдсэн, би үүнийг мэдэж байгаа гэж чи хэлэх гээд байна уу? Эсвэл чи намайг хий хоосон үгээр туршиж байгаа юм уу? Намайг мэхэлж нууцыг дэлгүүлэхийг хүсч байна уу?

- Би орхыг мэхэлдэг шиг нууцыг нь дэлгүүлэхгүй.

- Тэр яаж амь үрэгдсэн юм бэ, чи хаанаас олж мэдсэн юм бэ? Манай отрядаас хэн ч танай нийслэлд очоогүй гэж чи хэлээ биз дээ?

- Тэр яаж амь үрэгдсэн тухай би түүний найз, хамтрагчаас нь мэдэхийг хүсч байна.

- Гэвч би түүнийг амьд байхад нь салсан. Миний бодлоор бол тэр одоо ч амьд мэнд яваа. Гэхдээ одоо үхэл биднийг алхам тутамд дагаж байгаа даа.

- Тийм ээ, алхам тутамд. Хамгийн аюултай үхэл нь урвалт.

Сэм сонсон сонссоор тэвчээрээ барагдтал уурлав. Фарамирын сүүлчийн үгийг сонсоод тэр тал хүрээний дунд үсрэн хүрч эзэндээ хандав:

- Өршөөгөөрэй эзэн минь, миний бодлоор бол таныг хангалттай хэмлэлээ. Таныг ингэж байцаах энэ хэн юм бэ? Эцсийн эцэст та энэ бусдын ачийг боддоггүй үлэмж биетүүдийн төлөө л олон аюул, бэрхийг туулж яваа шүү дээ! – гээд Фарамирын өмнө очиж, Хоббитандаа байхдаа “Бусдын цэцэрлэгт юугаа хийж байгаа юм бэ” гэсэн асуултанд нь хэдэр хариулт өгсөн хүүхдүүдийг загнаж байгаа юм шиг ташаа тулан, хөлөө алцайсхийн зогсоод:

- За эрхэм жанжин! – гэтэл дайчид эгдүүцэн шуугилдав. Гэвч ихэнх нь доогтой инээж байлаа. Газар сууж байгаа сүрлэг баатар дайчин жанжных нь өмнө хөлөө алцайж, ташаа тулан ханхалзаж байгаа хилэнт хоббитыг харахад тэдэнд үнэхээр зугаатай байв. Ийм зугаатай юм өдөр болгон үзэх биш дээ!

- Чи юу гэх гээд юу гэчихэв? Хэлэх гэснээ шуудхан хэлчих, битгий тойрч давхиад бай, тэгэхгүй бол Мордороос зуун мянган орх одоохон ороод ирнэ шүү! Хэрэв чи манай эзэн танай Боромирыг алчихаад зугтаж явна гэж бодож байгаа бол чиний толгой хаанаа байгааг би мэдэж байна. Цаашдаа юу хийх гэж байгаагаа бидэнд хэлэхээ бүү мартаарай. Дашрамд хэлэхэд, Дайсны хамгийн гол дайсан гэж өөрсдийгөө нэрлэдэг зарим хүмүүс бусдын замд тээглэж байдаг, гэтэл тэр бусад нь өөрсдөөс нь ч их хэрэг бүтээж байгааг мэддэггүй нь харамсалтай. Дайсан чамд их баярлаж болох юм шүү. Чамайг бас нэг шинэ найз гараад ирлээ гэж бодох байлгүй!

- Аяар! - гэж Фарамир өчүүхэн ч уурласан шинжгүй хэлээд: - Эзнийхээ ярианд бүү саад бол, тэр хавьгүй илүү ухаантай. Цаг алдаж болохгүй гэдгийг би чамаас илүү мэдэж байна. Гэвч их хэргийн төлөө бэрх асуудлыг шийдэхийн тулд багахан цаг гаргасан юм. Чам шиг яаруу байсан бол би аль түрүүн та хоёрыг цавччих байсан юм. Учир нь Гондорын эзэн захирагчийн зөвшөөрөлгүйгээр энэ газарт тэнэж яваа хэн бүхнийг тэр дор нь цаазлах хатуу тушаал надад өгсөн юм. Гэвч би хэрэгтэй, хэрэггүй ямар ч шалтгаанаар алах дургүй. Үгээ ч салхинд хийсгэхгүй, итгэлтэй байж болно. Эзнийхээ дэргэд очоод дуугүй суу!

Сэм хавч шиг улайчихаад газарт лагхийн суув. Фарамир дахин Фродод хандаж:

- Чи Денэторын хүү амь үрэгдсэнийг яаж мэдэв гэж асуусан. Муу мэдээ жигүүртэй байдаг юм. Зүрх зүрхэндээ шөнийн цагаар мэдээ дамжуулдаг юм. Боромир миний төрсөн ах.

Түүний нүүрийг гашуудлын сүүдэр бүрхэв.

- Чамд Боромирын баатар вангийн зэвсэг хэрэгслээс ямар нэг санах юм байна уу?

Фродо шинэ урхинд орох вий хэмээн болгоомжилж, бас энэ бүхэн хаашаа эргэдэг бол гэж

бодсондоо хариулахаа азнасхийв. Тэр бөгжийг Боромирын хүчирхэг гарт алдахаас бараг л гайхамшгаар аврагдсан, гэтэл одоо олон хүчирхэг баатар вангуудын дунд зогсчихоод яаж авч гарах вэ гэдгээ бодож байгаагүй билээ. Гэвч Фарамир гадна төрхөөрөө ахтайгаа хичнээн адилхан ч түүнээс холын хараатай, болгоомжтой, мэргэн ухаантай гэдгийг зүрх нь хэлээд байгааг мэдрэв.

- Тийм ээ, би Боромирын бүрээг санаж байна.

- Хариулт зөв, байдлаас харахад үнэн ч юм юм шиг байна. Тэр бүрээг яг байснаар нь тод эргэн сана. Тэр бол дорнын аян дайны үеийн бүрээ. Мөнгөн чимэгтэй, эртний рун бичээстэй. Олон үеийн туршид түүнийг ахмад хөвгүүд эзэмшиж байсан. Бүрээг бэрх үед эртний Гондорын газар нутгийн хаанаас ч үлээхэд хаана ч дуулдана гэдэг байсан юм.

Би Итил рүү явахаас тав хоногийн өмнө, өнөөдрөөс арван нэг хоногийн өмнө үдээс хойш оройхон тэр бүрээний дууг сонссон. Гэхдээ их бүдэгхэн, хойт зүгээс дуулдсан юм. Эцэг бид хоёр үүнийг муу ёр гэж бодсон, яагаад гэвэл Боромирыг явснаас хойш ямар ч мэдээ ирээгүй, нэг ч хилийн харуул мэдээ өгөөгүй байсан юм. Гурав дахь хоногт нь би ер бусын юм үзсэн.

Би манантай шөнөөр Андуин мөрний эрэгт зогсоод, мөрний удаан урсгалыг харж, зэгс гашуудалтайгаар исгэрэхийг чагнаж байсан юм. Бид дайсанд эзлэгдсэн Осгилиатын эсрэг талын эрэгт шөнийн харуулд гарсан байлаа. Шөнө дундын тэр цагт эргэн тойрон нам гүм байсан. Гэнэт мөрний мандал дээр мөнгөлөг саарал өнгөтэй завь үзэгдэв. Харийн орных бололтой өндөр хушуутай завь өөрөө аяндаа хөвж байлаа.

Миний бие хүйт даагаад явчихлаа. Завийг тийм гэж хэлэхийн аргагүй саарал туяа хүрээлсэн байв. Гэвч би ямар нэг далдын хүчинд автаж, эрэг рүү буугаад ус руу орлоо. Завь над руу эргэж, удаанаар хөвж ирэхэд нь би гараа сунгах зүрх хүрсэнгүй. Гэтэл завь хүнд ачаагаа даахгүй байгаа мэт доош суув. Гэрэлтсэн тунгалаг ус бараг завины ирмэг хүртэл дүүрч, дотор нь амьгүй болсон баатар ван нойрсч байв. Тэр тоолшгүй олон шархтай, хугарсан илд нь өвдөг дээр нь хэвтэж байв. Тэр бол миний ах Боромир байсан бөгөөд би түүнийг илд, хуяг дуулга, хайр булаасан царайгаар нь таньсан. Түүний бүрээ нь байхгүй, алтан навчаар хийсэн юм шиг бүс нь танил биш байв.

“Боромир! Бүрээ чинь хаа байна, Боромир? Хаашаа хөвж яваа юм бэ чи, Боромир?” – гэж би хашгирсан. Гэвч завийг урсгал хаман авч, шөнийн харанхуйд мөнгөрөн гялалзсаар далд оров. Би зүүдэлснээ, хий үзэгдэл байсан уу, бодитой болсон явдал уу гэдгийг тэрхэн үедээ мэдээгүй боловч ах маань байхгүй болсон, түүний шарил Их мөрнөөр хөвөөд явчихлаа гэж багтай мэдэрч байсан.

- Чиний ярьсан зүүднээс би Боромирыг нүдээрээ харсан юм шиг таньж байна. Алтан бүсийг хатан хаан Галадриэль бэлэглэсэн юм. Бидний энэ эльф цувийг ч бас тэр өгсөн. Лориэний зүүлт энэ байна – гээд Фродо хүзүүндээ байгаа мөнгөлөг ногоовтор зүлтээ заав.

Фарамир түүнийг үзээд:

- Гоё зүүлт байна. Тэр бүснийхтэй ижил хийцтэй юм байна. Тэгэхлээр та нар Лориэнээр

дайрч ирсэн хэрэг үү? Хуучнаар Лаурелиндоренан гэж нэрлэдэг байсан юм. Тэнд хүний хөл гишгээгүй их удсан даа – гэж Фарамир аяархан хэлээд Фродо руу ихэд гайхан хараад:

- Одоо надад хачин санагдаж байсан зүйлсийн ихэнх нь ойлгомжтой боллоо. Өөр ямар нэг юм хэлж өгөхгүй юм уу? Яагаад гэвэл, яагаад Боромир ганцаараа төрөлх нутгийнхаа захад ирээд амь үрэгддэг билээ гэж бодохоос л миний гол харлаад байна.

- Чиний сэтгэлийг амраах юу ч хэлж чадахгүй. Чиний яриа надад түгшүүр төрүүлж байна. Чиний үзэгдэл харсан уу, эсвэл тэр өнгөрсөн үеийн юм уу, ирээдүйн золгүй явдлын мэдээ байсан уу, би мэдэхгүй. Харин дайсны зориуд үзүүлсэн тоглолт л биш байгаасай. Би Үхдлүүдийн намгийн усанд эртний баатруудын сайхан царайг харсан, гэтэл энэ нь Дайсны хар шид байсан.

- Үгүй ээ, энд тэр хамаагүй. Тэрний хар шидийн илбэ сэтгэл зүрхийг хүйтрүүлж, ой гутаадаг бол миний хувьд тэр үзэгдэл зүрхийг минь уй гашуу, сэтгэлийн зовлонгоор дүүргэж байсан.

- Тийм зүйл яаж бодитойгоор тохиолдох билээ? Тол-Брандирын хүрхрээг нэг ч завь эвдрэлгүйгээр давж чадахгүй, Боромир Онтава голоор, Ристанин талаар нутаг руугаа буцах гэж байсан. Усаар дүүрсэн өвчүү завь хүрхрээгээр давахдаа хөмрөөгүй байж болох уу?

- Мэдэхгүй юм даа, завь хаанаас авсан юм бэ?

- Лориэнээс, бидэнд тийм завь гурав байсан, бид Андуинаар хүрхрээ хүртэл сэлүүрдсэн. Эльфийн завь л даа.

- Та нар хаалттай оронд очжээ. Түүний ид шидийг тайлах ухаан та нарт байхгүй. Алтан ойн шидэт хаган хаантай уулзсан хүн юунд ч гайхахгүй. Үхэлт амьтад манай саран доорх ертөнцөөс гарах аюултай. Тэд эргэж ирэхдээ өмнөхөөсөө огт өөр болсон байдаг юм. Домогт тэгж өгүүлдэг – гэснээ тэр гүнээ сүүрс алдаад:

Боромир минь дээ, Боромир минь! Үхэшгүй мөнхийн хатан хаан чамд юу хэлчихэв дээ? Чиний зүрхнээс тэр юу олж хараад, юу сэрээж орхив доо? Яах гэж чи Лаурелиндоренан руу явав аа, яагаад өөрийнхөө замыг хөөж, сэрүүн тунгалаг өглөөгүүр ристанийн хөлгөөрөө давхиад ирсэнгүй вэ? - гэж халаглан өгүүлснээ дахин Фродо руу эргэж ихэд тайвнаар:

- Энэ бүх асуултад Дрогогийн хүү Фродо чи хариу өгч чадах биз. Гэхдээ энд биш, одоо биш. Гэвч чи намайг хар эзний нөлөөнд авгаж хий юм харжээ гэж бодохгүйн тулд Боромирын бүрээ бодитойгоор эргэж ирсэн гэдгийг мэд, тэгэхдээ сүх юм уу, илдэнд хоёр хуваагдсан байсан. Нэг хэсгийг нь Гондорын харуулууд умард хязгаарын зэгсэн дунд, Онтавагийн хүрхрээний доохноос олсон, нөгөө хэсгийг нь Андуины буланд нэг шумбагч олсон. Хачирхалтай тохиолдууд үхлийг нуухгүй гэж ярьдаг биз дээ. Одоо ахмад хүүгийнх нь эзэмшиж явсан бүрээний хугархай Денэторын өвдөг дээр байгаа. Тэр өндөр хаан ширээн дээ суугаад аймшигт мэдээг хүлээж байна. Бүрээг яаж цавчсан талаар чи ярихгүй юм биз дээ?

- Мэдэхгүй юмныхаа тухай үг дуугарахгүй. Хэрэв чи өдөр хоногоо зөв тоолсон бол би зарцтайгаа хамт нөхдөөсөө салсан тэр өдөр чи бүрээн дууг сонссон байна. Одоо чиний яриа

намайг айдсаар дүүргэж байна. Хэрэв

Боромирт гай тохиолдож, алагдсан бол миний бүх хамтрагчид, нутгийн хоёр болон бусад андууд минь бүгд амь үрэгдсэн байна. Чи надад эргэлзэхээ болиод явуулчих юм биш үү? Би их ядарсан, уй гашуу, айдас хоёр намайг тарчлааж байна. Гэвч би нэг юм хийх ёстой, намайг алаагүй байгаа цагт ядаж хийх гэж оролддох ёстой юм. Хэрэв биднээс ердөө хоёр жижиг биет амьд үлдсэн бол бүр ч их яарах хэрэгтэй байна.

Гондорын эрэлхэг жанжин Фарамир минь, нийслэлдээ эргэж очоод сүүлчийн дусал цусаа дуустал хамгаал, харин надад хувь тавилангийнхаа өөдөөс явах боломж олго!

- Чиний ярианд миний сэтгэлийг тайтгаруулах юм бага байна, гэхдээ дэмий айж байна. Хэрэв Лориэний эльфүүд биш юм бол Боромирыг хэн сүүлчийн замд нь баатрын ёсоор үдэж гаргасан байх вэ? Орхууд, дайсны гар хөл бологсод биш байж таарна. Танай отрядаас нэг нь ч гэсэн амьд байна гэсэн үг. Гэвч, манай хилийн ойролцоо юу ч болсон байлаа гэсэн Фродо чи сэрдлэгээс цэвэрлэгдлээ. Манай энэ цөвүүн цагт би хүмүүсийг нүүр царай, хэл яриагаар нь дүгнэж цэгнэж байгаа бол жижиг биетүүдийн тухайд ч гэсэн алдахгүй байж магадгүй! Гэхдээ чамд ямар нэг хачирхалтай юм байна Фродо, эльфийнх биш биз? – гээд тэр анх удаа инээмсэглэж:

- Бидний яриа миний эхэндээ төсөөлж байснаас хавьгүй чухал. Би чамайг Минас-Тиритэд Денэторын өргөөнд аваачих ёстой. Би ард түмэндээ хор хүргэх үйлдэл хийвэл цаазаар хороогдох болно. Тиймээс шийдвэр гаргахдаа яарч болохгүй, одоо шууд замдаа гаръя.

Тэр ухасхийн босч, тушаал өгөв. Дайчид нь хоромхон зуурт жижиг отрядууд болон салж, моддын дундуур алга болов. Төдөлгүй зөвхөн Маблунг, Дамрод хоёр үлдэв.

- Фродо, Сэммиум та хоёр надтай болон миний хамгаалагчидтай хамт явна. Тэртэй тэргүй өмнөдийн зам та хоёрын хувьд хаалттай. Хэдэн өдрийн турш тэр замыг цэргээр дүүргэнэ. Өнөөдрийн байлдааны дараа харуул хамгаалалтыг арав дахин нэмэгдүүлнэ. Тэгээд ч өнөөдөр та хоёр хөл дээрээ дөнгөж тогтож байгаа юм чинь хол явахгүй. Бид ч гэсэн ядарсан. Бидэнд эндээс арваад бээрийн зайтай нууц хуаран бий. Орхууд болон дайсны бусад цэргүүд түүнийг тагнаж олоогүй байгаа. Оллоо ч гэсэн нүцгэн гараараа бариад авчихгүй, бүтэн арми авчраад ч багадна. Тэнд бага зэрэг амарна, та хоёр ч гэсэн. Цаашид яах вэ, та хоёрыг яах вэ гэдгээ маргааш өглөө би шийднэ.

Фродо энэ зайлшгүй урилгыг хүлээж авахаас өөр арга байсангүй. Үнэхээр гондорчуудын өнөөдрийн ялалтын дараа Италийг дамжин гарах гэдэг өмнөхөөсөө олон дахин аюултай билээ. Тэд замдаа гарав. Маблунг, Дамрод хоёр түрүүлж, Фарамир хоббитуудын хамт араас нь явав. Тэр гурвын угаал хийсэн цөөрмийн хажуугаар гарч, горхиор гатлаад, нэгэн өндөр толгойг давж, дараа нь баруун тийш эргэж, ой дундуур эгцлэн уруудав. Фарамир хоббитуудын шогшоонд алхаагаа тааруулан, аяархан ярилцаж явлаа.

- Бид ноён Сэммиумын надад сануулсанчлан цаг хугацаа биднийг хүлээхгүй гэсэн шалтгаанаар төдийгүй, илүү чих байлгахгүйн тулд таарч яваа юм. Нууцаар ярилцах зүйл байна. Би Исулдурын хараалт шидийг үл хэрэгссэн ахынхаа хувь заяанд яриагаа шилжүүлсэн

нь дэмий хэрэг биш. Чи олон юм нуусан шүү, Фродо.

- Би бүх үнэнийг хэлээгүй ч гэсэн нэг ч худал үг хэлээгүй.

- Би чамайг буруутгаж байгаа юм биш ээ. Чи маш хүнд сорилтыг нэр төртэй давж гарсан, ховорхон ухаантай хүн. Гэвч би чиний ярианы цаана байгаа зүйлийг ч харж байна. Боромиртой чи найз байгаагүй, салахдаа базаахгүй салсан. Тэр чамайг болон ноён Сэммиумыг гомдоосон байх. Би Боромирт дэндүү хайртай, түүний хариуг авахдаа л авна. Гэхдээ би түүнийг их сайн мэддэг байсан юм. Исилдурын хараалт шидээс болж та хоёр муудалцсан байж таарнаа даа. Тэрнээс болж л танай отряд салсан биз дээ? Тэр бол асар хүчтэй сахиус, хуучны домогт итгэх юм бол анд нөхдийн хооронд хэрүүл тэмцэл үүсгэдэг сахиуснуудын нэг гэж би мэдэж байна. Би зөв таасан уу?

- Зөв, гэхдээ яг бүрэн биш. Манай отрядад санал зөрөлдөөн байгаагүй, харин Дайсны хөндийгөөс хаашаа явах вэ гэсэн эргэлзээ байсан. Хуучны домгийн тухайд гэвэл, ... сахиусны тухай ярьж байгаа бол илүү үг унагаж болохгүй гэж биднийг сургадаг.

- Тэгэхлээр анх миний бодсончлон ганцхан Боромиртой л санал зөрөлдсөн байх нь. Тэр сахиусыг Минас-Тиритэд авчрах гэсэн байна. Хувь тавилан ямар гунигтай зурагдаа вэ? Түүнийг хамгийн сүүлд харсан чиний амыг сахиус хааж, чи надад гол зүйлийн тухай, үхэхийн өмнө түүний зүрх сэтгэлд байсан гол зүйлийн тухай ярьж чадахгүй байдаг. Тэр төөрөлдсөн эсэхийг би мэдэхгүй, гэвч тэр нэр төртэй үхэж, өөрийгөө ялсан гэдэгт итгэлтэй байна. Түүний царай амьд байхынхаасаа ч гоё сайхан байсан.

Намайг уучлаарай, Фродо, би эхлээд Исилдурын хараалт шидийн талаар чамаас үг авах гэж илүү шалгаасны төлөө. Цагаа ч олоогүй, газраа ч олоогүй явдал болсон. Би бодож амжаагүй юм. Тулалдаан их ширүүн болсон, надад өөр шийдэх бэрх асуудлууд байсан. Дөнгөж санаа авангуутаа би яриагаа өөр тийш нь чиглүүлсэн юм. Яагаад гэвэл эзэн захирагчид бид бусад хүмүүст хүртээлгүй эртний мэргэн ухаанд нь хамааралтай байдаг юм. Бид Элендилийн шууд удам биш, гэвч бидний зүрхэнд адилхан л нуменорын цус гүйж байгаа. Бид бол Анарионы удмын сүүлчийн их ван Эарнур аян дайнд мордохдоо эзэн захирагчаар үлдээсэн Мардилын удам. Хаан дайнаас эргэж ирээгүй, тэр угсаа залгамжлах хүүхэдгүй байсан юм. Тэр цагаас хойш олон зууны туршид манай орныг эзэн захирагч удирдаж ирлээ.

Боромир бид хоёр хүүхэд байхдаа Гондорын түүх болон манай ургийн тухай түүх домгийг хамтдаа уншихад ах минь өвөг дээдсээ хаан биш гэж дандаа уурладаг байсан. “Хаан эргэж ирээгүй юм бол эзэн захирагч хаан болоход хэдэн зуун жил хэрэгтэй юм бэ?” гэж асуухад нь аав “Бусад оронд хэдэн арван жил л хангалттай, Гондорт бол арван мянган жил хангалтгүй “ – гэж хариулж байсан юм. Хөөрхий Боромир минь! Энэ чамд түүний тухай ямар нэг юм хэлэхгүй байна уу?

- Хэлж байна аа, гэхдээ тэр Арагорныг үргэлж хүндэтгэдэг байсан.

- Тийм бий, хэрэв тэр Арагорны их хааны ширээнд суух эрхийг хүлээн зөвшөөрч байсан юм бол өөрийгөө түүний албат гэж хүлээн зөвшөөрч байжээ. Гэвч хамгийн хүнд сорилтод тулж очоогүй байна. Дайн тэр хоёрыг дайсан болгож хувиргасан бол Минас-Тиритэд юу болохыг

хэн мэдэх билээ. Гэвч би хадуурчихлаа. Денэторын удам эртнээс эртний мэргэн ухаанд хамааралтай гэж би хэлсэн. Манай эрдэнэсийн санд пергамент, чулуу, лаи, мөнгөн хуудсан дээр бичсэн эртний номууд болон олон хэл дээрх захидлууд байдаг. Хэн ч уншиж чадахгүй олон ном байдаг учир тоосонд дарагдаад л хэвгэж байдаг. Би тэдэнтэй их зууралдсан учир надад эрдмийн эх бий шүү. Эдгээр эрдэнэсийг үзэхийн төлөө манайд Саарал тэнүүлч ирдэг байсан, бүр хүүхэд байхад л би түүнийг анх харсан, түүнээс хойш хоёр, гурван удаа л ирсэн.

- Саарал тэнүүлч гэнэ ээ? Нэрийг нь хэн гэдэг юм бэ?

- Бид түүнийг эльфээр Митрандир гэдэг байсан юм, түүнд ингэж дуудах нь таалагддаг байсан юм. “Намайг янз бүрийн газарт янз бүрээр дууддаг. Эльфүүд Митрандир гэнэ, гномууд – Таркун гэнэ, нэгэн цагт баруун газарт би Олорин нэртэй байсан, өмнөдөд - Инканус, умардад - Гэндалф, дорнод газарт би очдоггүй” – гэж ярьж байсан.

- Гэндалф! Би тэгж бодсон юм аа. Саарал Гэндалф бол бидний анд бөгөөд зөвлөх. Манай Отрядын удирдагч. Тэр Мориид амь үрэгдсэн.

- Митрандир амь үрэгдсэн гэнэ ээ! Та нарт ч хатуу хувь тохиож дээ. Тийм агуу их мэргэн, хүнд бэрх цагт манай найдвартай туслагч үхэж болно гэдэгт итгэх ч арга алга, энэ ертөнц ижилгүй их эрдмээ алдаж дээ. Тэр амь үрэгдсэн гэдэгт чи итгэлтэй байна уу? Өөр хойшлуулшгүй ажил гараад та нарт хэлж амжилгүй явчихсан юм биш үү?

- Итгэлтэй байна. Түүнийг ёроолгүй харанхуй залгиж байхыг би харсан.

- Чиний энэ үг аймшигтай түүхийн эхлэл байх аа. Чи орой тэр тухай ярьж өгөх үү? Одоо надад их хэцүү байна. Митрандир зөвхөн мэргэн, их номч байсан төдийгүй манай үеийн хувь заяаг шийдэгч байсан нь одоо надад тодорхой боллоо. Тэр ах бид хоёрыг зүүдэндээ ирээдүйн зөнг сонсоход Гондорт ирсэн бол түүний утгыг тайлж өгөх байсан юм. Тэгээд Уудам хөндийн орон руу элч илгээх шаардлага гарахгүй байсан болов уу. Тэр тайлбарлахгүй ч байсан байж магадгүй, Боромир ч тавилангаасаа зайлахгүй байсан байж магадгүй. Митрандир бидэнд хэзээ ч ирээдүйг урьдчилж хэлдэггүй, өөрийнхөө санааг хуваалцдаггүй байсан. Тэр Денэторын зөвшөөрлийг яаж авсан юм мэдэхгүй, ямар ч гэсэн түүний зөвшөөрлөөр манай эрдэнэсийн санд ордог байсан, би түүний эрдмийн дөнгөж нээгдэх төдийн их сангаас хүртэж байсан. Тэр их харамч багш байсан юм.

Ялангуяа Дагорладын талд болж, миний нэрийг нь дурдахгүй байгаа тэрний ялагдсан агуу их тулалдааны болон Гондор улс байгуулагдсан үеийн түүхэн бичиг, аман домгуудыг их сонирхдог байсан юм. Исилдурын тухай ч их асуудаг байсан. Харамсалтай нь манай түүхэн бичигт тэр тухай хадгалагдаж үлдээгүй.

Фарамир шивнэн ярьж эхлэв:

- Би заримыг нь олж мэдсэн, заримыг нь өөрөө нэмж дүгнэсэн, тэгээд гүнзгий нууцалж явдаг зүйлээ ярья. Исилдур Дайны нэгэн үнэ цэнэтэй зүйлийг гартаа оруулжээ. Түүнийг Гондороос үхлийн өөдөөс явахдаа авч гарсан юм. Тэгээд Митрандир юуг ингэж их хайгаад байгааг ойлгох шиг болсон, гэхдээ өнө эрт цаг руу чиглэсэн энэ эрэл ердөө л их номчийн

мэргэн ухаан гэж бодсон юм. Гэвч бид нууцлаг зөнг тайлах гэж оролдоход тэр олз нь Исилдурын хараалт шид юм байна гэж таамагласан. Яагаад гэвэл бид өөр юу ч мэдэхгүй байгаа, зөвхөн Исулдур орхын суманд оногдсон тухай нэг домогт дурдсан төдий юм. Митрандир надад зөвхөн үүнийг л хэлсэн. Исилдурт байсан чухам ямар зүйл нь дайсанд тийм хэрэгтэй болсныг мэдэхгүй, бодвол ямар нэг хар эзний хорт муу үйлийн зэвсэг болсон ямар нэг асар хүчирхэг, үхлийн сахиус байх. Хэрэв тэр сахиус дайн байлдаанд амжилт авчирна гэсэн итгэл байгаа бол бардам, аймшиггүй, заримдаа эргэж харахгүй тэнэглэдэг, Минас-Тиритийн ялалтын төлөө, өөрийнхөө дайчин алдрын төлөө яахаас ч буцахгүй Боромир тэр зэвсгийг гартаа оруулах гэж тэсгэлгүй их хүссэн. Тэр тун ч цөвүүн цагт Уудам хөндий рүү зүглэж дээ! Эцэг минь ч, ахмадууд ч намайг илгээх байсан, гэтэл ахмад хүү, хатуужсан дайчин, надтай эгнэшгүй баатар ван өөрийнхөөрөө зүтгэсэн.

Битгий гайхаарай! Би тэр сахиусыг их зам дээр хэвтэж байсан ч авахгүй байсан. Тэр ч байтугай Минас-Тирит миний нүдний өмнө сөнөж, ганцхан би л дайсны тэр шидэт зэвсгийн хүчээр Гондорыг аварч, агуу хүчирхэг гүрэн болгон, өөрөө алдрын тэнгэрт мандах байсан ч авахгүй! Тийм үнээр надад ялалт ч, алдар нэр ч хэрэггүй, Дрогогийн хүү Фродо минь.

- Зөвлөл ч гэсэн тэгж шийдсэн. Тэр надад хэрэггүй, ер нь энэ бол миний хийх ажил биш.

- Миний мөрөөдөл бол цэцэглэж буй Цагаан мод, хааны тэргүүн дээрх мөнгөн титэм, энх амгалан Минас-Тирит – биш ээ, эрт цагт ямар байсан шигээ гэгээн саруул, өндөр, гайхамшигтай, хаадын хаад шиг сайхан Минас-Анор хот болохоос биш, боолуудаар хүрээлүүлсэн аймшигт эзэн биш, боолууд нь эзэндээ сэтгэл хангалуун байлаа ч гэсэн тийм эзэн болж хэрэггүй. Байлдах хэрэгтэй байна. Бид өөрсдийн амьдрал, нэр төрөө алуурчин, харгислан тамлагч, хөнөөн сүйтгэгчээс хамгаалж байна. Гэхдээ надад хурц илдийн гялбаа ч, хурдан сумны исгэрээ ч, агуу баатар вангийн алдар ч таалагддаггүй. Энэ бүхэн зөвхөн бид хамгаалж байгаа юм аа хамгаалахад л хэрэгтэй. Нуменорчуудын байгуулсан гэгээн саруул хотоо, ой дуртгалын тулгуур, эртний мэргэн ухааны их сан, гоо сайхны нандин шүтээн, амьд үнэний гэрэл гэгээ болсон хотоо хамгаалахад л хэрэгтэй. Түүнийг маань хайрлах болохоос түүнээс минь айхгүй байхын төлөө, мөнгөн буурал тэргүүнт мэргэдийг хүндэтгэдэг шиг хүндэтгэж байхын төлөө бид тулалдаж байгаа юм.

Тийм учраас айж болгоомжлохоо боль! Би чамаас дахиад асууж шалгаахгүй, би зөв таасан уу гэж асуух ч үгүй. Хэрэв чи надад итгэвэл би чамд зөвлөгөөгөөрөө, болж өгвөл үйл хэргээр тус хүргэхийг хичээе.

Фродо юу ч хэлсэнгүй. Тэрбээр энэ хатуу ширүүн дүртэй залуугаас тусламж зөвлөгөө гуйх хүсэлдээ бараг бууж өгөх дөхөв. Түүний яруу тод яриа үнэхээр гойд баяр талархал төрүүлж байлаа. Гэвч ямар нэг юм түүнийг барьж тогтоогоод байв. Түүний зүрхэнд айдас, түгшүүр байлаа. Есөн хадгалагчаас ердөө Сэм бид хоёр л амьд үлдсэн юм бол бүгдийн өмнөөс бид хоёр л хариуцлага үүрэх ёстой. Сэрдлэг сохор итгэлээс илүү найдвартай гэж тэр бодож байв. Тэгээд ч дэргэдээ явж байгаа өндөр дайчинг харж, түүний дуу хоолойг сонсоход төр өөрийн эрхгүй Боромирыг санаж байв. Түүний гэнэт татваганасан царай, нүдэнд нь дүрэлзэх шуналын гал харагдаад байв. Огт адилгүй ах, дүү хоёр аймшигтай адилхан харагдаж байлаа.

Дараа нь тэд ногоон саарал сүүдэр мэт хөгшин моддын дундуур өвсөн дээр чимээгүйхэн

гулссаар дуугүй алхацгаав. Тэдний дээгүүр шувууд жиргэн, Италийн ойн мөнх ногоон навчис бүдэгхэн гялалзаж байлаа.

Сэм ярианд оролцсонгүй, дуугүй сонсч явахдаа хоббитын мэдрэмтгий сонор чихээрээ орчны ойн чимээ бүгдийг соргог сонсч байв. Хорлумын талаар нэг ч үг сонсогдсонгүйд тэр баяртай байв. Наалданхайгаас сална гэж байхгүй боловч, түүнгүйгээр бага ч гэсэн амрахад таатай байлаа. Төдөлгүй тэр хэдүүлэхнээ, өмнө нь Дамрод, Маблунг хоёр, араас нь тэр гурав явж байгаа боловч эргэн тойронд нь үй олон хүн хамт явж байгааг мэдэв. Хурдан, чимээгүй, дөнгөн данган гяля гялс үзэгдэх мөрч дайчид товлосон газар руугаа яарч яваа ажээ.

Гэнэт хэн нэгний харц нуруу руу нь хатгах шиг болоход түргэн эргэж харвал модны цаагуур гялсхийн орж байгаа жижигхэн бараан дүрсийг харж амжлаа. Сэм амаа нээх гэснээ бодосхийгээд дуугарсангүй. “Тэгж санагдсан ч байж болно. Тэгээд ч би тэр новштой хамт эдэн дээр очоод яах юм бэ. Тэрнийг дурсах ч үгүй байхад ганцхан надад л хэрэгтэй юм уу?” гэж бодов.

Тэгсхийгээд ой шингэрч, уулын хажуу эгцэрч ирэв. Тэд баруун тийш эргэж, нөгөөх байгалийн бассейнаас эх авсан горхин дээр ирэв. Горхи энд их ширүүн урсгалтай болсон байх бөгөөд чулуурхаг голдрил нь хоёр талаараа модоор нягт хашигдсан нарийхан хавцал руу оржээ.

- Одоо би найрсаг биш зантай болохоос өөр аргагүй. Намайг уучилна гэж найдаж байна. Одоогоор би бүх тушаалыг зөрчиж, та нарыг алаагүй, ядаж сохлоогүй байна. Гэвч энд хатуу хориотой. Энэ жимийг хэн ч мэдэх ёсгүй, бүр холбоотон ристаничууд маань ч мэдэх ёсгүй. Та нарын нүдийг боох хэрэгтэй боллоо.

- Тэгэлгүй яах вэ, эльфүүд ч гэсэн чамаас найрсаг байгаагүй, бид гайхамшигт Лориэн руу нүдээ боолгож орсон. Гном Гимли их гомдож байсан, хоббитууд бид тэр зэргийн юм тоохгүй.

- Би та нарт сайхан юм амлаж чадахгүй, гэхдээ та нарыг албадахгүй, цагдахгүй байгаа нь сайхан.

Фарамир аяархан дуудахад Маблунг, Дамрод хоёр модны цаанаас тэр даруй гарч ирлээ.

- Зочдын нүдийг боо. Сайн боо, тэгэхдээ чанга биш. Гарыг нь хүлэх хэрэггүй. Тэд нууцаар харахгүй. Би эд нарт итгэж байгаа учраас нүдийг нь боохгүй, зүгээр л нүдээ аниад яв гэж хэлж болно. Гэвч цаг цөвүүн байна. Санамсаргүй бүдэрч унаад нүдээ нээчихвэл яана. Санаснаас бүдрүүлэхгүй байх талаас нь хичээгээрэй.

Хамгаалагчид хоёр хоббитын нүдийг ногоон алчуураар боож, юүдэнг нь дарж өмсгөөд гараас нь хөтлөв. Нарлаг Италийн зугаалга төгслөө.

Фродо, Сэм хоёрын хувьд хаагуур аялснаа зөвхөн тааж л болох байлаа. Эхлээд эгц жимээр уруудаж, чулуун ханануудын хоорондуур нэг нэгээрээ цувж явав. Хамгаалагчид тэр хоёрыг ардаа оруулаад мөрөн дээрээс нь татаж явлаа. Нүд боолттой явж болохооргүй газарт тэр хоёрыг хүүхэд мэт өргөн гараад, гармагцаа тавьж байлаа. Баруун талаас ус хүржигнэн бууж, цалгих чимээ гарснаа удалгүй улам ойртон чангарав. Эцэст нь тэд зогслоо. Маблунг, Дамрод

хоёр хоббитуудын зүг чигийн баримжааг алдуулахын тулд хэсэг эргүүлээд, дараа нь жим дээш өгслөө. Усны чимээ холдож, сэрүүхэн болов. Тэр хоёрын гараас хөтөлж ямар нэг шатаар доош буув. Нэг хясааны булан тойроход дахиад эргэн тойронд ус хүржигнэх сонсдов. Тэднийг усан цацрагаар шүршиж байх шиг. Дахиад л нүд нь боолттой чигээр, айж сандарсан хоёр хоббит чимээгүй зогсч байтал ард нь Фарамирын дуу гарав:

- Нүдний боолтыг ав! – гэж тэр тушаалаа. Юүдэнг арагш буулган, боолтыг тайлахад тэр хоёр гялбаж, нүдээ цавчлав.

Тэд хадан хясаанд нүхэлж гаргасан хаалганы өмнөх толигор чулуун хавтан дээр зогсч байв. Тэдний өмнө гар сунгахад л хүрэхээр ойрхон зайд жаргаж буй нарны туяагаар гийгүүлэгдсэн усан хөшиг намирч байлаа. Нарны улаан туяа усан хөшигнөөс ойж солонгын өнгөөр алаглан задарч байв. Тэд янз бүрийн эрдэнийн чулуугаар чимэглэсэн алт, мөнгөн утсаар нэхсэн эльф цамхагийн цонхны дэргэд байгаа юм шиг санагдав.

- За, та нарын тэвчээрийн шагнал энэ дээ. Нар жаргахаас нэг хоёрхон минутын өмнө амжиж ирлээ. Энэ бол Хеннет-Аннун буюу Жаргах нарны цонх, түүний өмнө Итилиин хамгийн гоё хүрхрээ байна. Энд ядаж ганц харийн хүн ирж байсан уу, үгүй юу мэдэхгүй юм. Өргөө нь цонхоо бодвол энгийн, хааны өргөө биш шүү дээ, гэвч өөрсдөө орж үз дээ!

Нар жаргаж, усан хөшиг бүдгэрэв. Тэд намхан нуман хаалгаар дамжиж, олон тасалгаатай маш том агуйд оров. Бамбаруудын гэрэл хананууд дээр бүдэгхэн тусан тоглоно. Энд олон дайчид цугларсан ч гэсэн хажуугийн нарийхан хаалгаар нэмэн хоёр гурваараа орж ирсээр байна. Нүд дасаад ирэхээр агуйг тойруулан харвал анх санагдсанаасаа хамаагүй уужим зайтай бөгөөд зэр зэвсэг, хоол хүнсний агуулах ч байрлажээ.

- Манай хуаран энэ дээ, тансаг тавилга байхгүй боловч тайван, тав тухтай хоноцгоо. Хуурай, хоол унд хангалттай, харин гал л байхгүй дээ.

Нэгэн цагт энэ ус гаргах агуй байсан юм. Тэр харагдаж байгаа нуман хаалгаар гаргадаг байсан боловч эртний чулуучин мастерууд өөрчилж, одоо биднээс нэлээд өндөрт байгаа хясаанаас оргилж байгаа. Энэ агуйн бүх нүх сүвийг бөглөсөн, ус ч, чөтгөр ч орж ирэхгүй. Зөвхөн сая та нарын нүд боолттой орж ирсэн хаалга л байна. Өөр нэг гарц нь усан цонхоор хурц асгаар дүүрэн нуур руу гарч болно. Амарцгаа, бүгд цугларч, хоолны цаг болохоор дуудна гэв.

Хоббитуудыг нэг буланд гаргасан жижигхэн лоожид байрлуулав. Хоол ундыг хурдан, яаралгүй бэлдэж байна. Хананаас ширээний тавцан гаргаж ирээд эвхмэл хөл дэлгэн тавьж, дээр нь аяга, таваг өрөв. Цэвэр цэмцгэр, нягт нямбай, энгийн уур амьсгал ноёлжээ. Дунд талын онцгойдуу ширээнд Фарамирт зориулсан мөнгөн хундага тавьжээ.

Фарамир агуй дотуур явж, шинээр ирэгсэдтэй аяархан ярилцаж байна. Дайчдын зарим хэсгийг бутцохигдсон дайсны үлдэгдлүүдийг мөрдөн устгах, зарим хэсгийг замын харуулд гаргасан бөгөөд харуулд гарагсадоройтосхийж ирэв. Аварга том мумакаас өөр нэг ч амьтан амьд гараагүй ба мумакийг мөрдөлгүй орхижээ. Дайсны цэргүүд үзэгдээгүй, орх тагнуулчид ч алга гэнэ.

- Чи ч гэсэн юу ч үзэж, сонссонгүй юу Анборн? - гэж Фарамир дөнгөж орж ирсэн дайчнаас асуув

- Сураг ч алга, бараа ч алга эзэнтээн, орхууд хаа нэг тийш талийсан байна. Харин нэг хачин амьтан шиг юмыг харав уу, харсан юм шиг санагдав уу, бүү мэд. Бүр бүрэнхий болсон хойно, харагдах бараа бүхэн томорч харагддаг үест. Бодтол хэрэм биз – гэхэд нь Сэм чих тавин чагнав. – Гэхдээ хэрэм гэтэл хар, бас сүүлгүй. Чи ан амьтныг дэмий бүү хөнөө гэж тушаасан болохоор би харвасангүй. Харанхуй ч байсан, тэр амьтан нүд ирмэх зуурт навчсын цаагуур далд орсон. Яг ч хэрэм биш болохоор нь жаахан зогсч хүлээсэн. Тэгээд явж байтал тэр амьтан миний дээр исгэрэх шиг болсон. Дайснаас зугтаасан амьтан байж болно. Бөглүүд ойгоос амьтад наашаа дүрвэж байгаа. Тэнд хар хэрэм үржүүлдэг гэсэн.

- Магадгүй л юм, гэхдээ энэ муу мэдээ. Бидэнд Бөглүүд ойн оргодлууд дутаж гэнэ.

Фарамир ингэж хэлээд хоббитууд руу харах шиг Сэмд санагдав. Гэвч Сэм дахиад л дуугүй байхаар шийдэв. Фродо тэр хоёр зэрэгцэн хэвтээд, бамбаруудын гэрэл болон нааш цаашаа явж, аяархан ярилцан байгаа хүмүүсийг харж байснаа Фродо нам унтаад өглөө. Сэм өөртөө унтахгүй байх тушаал өгөв.

“Мэдэж цөхөх юмгүй. Хүмүүстэй хамаагүй харилцаж болохгүй. Үг нь сайхан гэж жигтэйхэн, үгээрээ л чамайг аргалчихна. Долоо хоног унтчих юмсан, тэгвэл ч ёстой цоо шинэхэн болно доо. Унтахгүй байлаа гээд ямар нэг юм болвол яах билээ? Энэ олон үлэмж биетнүүдэд ганц хоббит юу болоо аж. Гэлээ ч гэсэн битгий унт, Сэм Скромби, унтах гэж бодсоны ч хэрэггүй!” – гэж бодов. Тэгээд унтах тухай бодсонгүй. Хаалганы нээлхий бүүдгэрч, саарал усан хөшиг харанхуйд алдрав. Зөвхөн унаж буй усны нэгэн хэмийн шуугиан үдэш ч, шөнө ч, өглөө ч тасарсангүй. Усны нэгэн хэмийн чимээ бүүвэйлэхэд Сэм нүдээ нударгаараа хурдан хурдан арчив.

Шинэ бамбарууд асаалаа. Торх дарс өнхрүүлэн авчирч, хоол өрж, хүрхрээнээс ус авчирч байна. Гараа угаацгаалаа. Фарамирт зэс түмпэн, цасан цагаан алчуур авчрав.

- Зочдыг сэрээ, гар нүүрийг нь угаалга, хоолны цаг боллоо – гэж тэр хэлэв. Фродо өндийн суугаад эвшээж, сунналаа. Сэмийн дээрээс нэгэн өндөр дайчин түмпэнтэй ус барин тонгойход түүн рүү их тэд гайхан ширтэв:

- Шалан дээр тавьчих аа, ноёнтоон, болно биз дээ, танд ч, надад ч эвгэйхэн – гэж Сэм хэлэв.

Тэрбээр түмпэнтэй усанд толгойгоо дүрээд, хүзүү, чихээ хүйтэн усаар тургин байж шавшихад эргэн тойронд нь байгаа дайчид инээдээ барьж ядан харж байв.

- Танайд оройн хоолны өмнө заавал хүзүү толгойгоо угаадаг уу? – гэж түүнд үйлчилж байгаа дайчин асуув.

- Үгүй дээ, голдуу өглөөний хоолны өмнө, гэхдээ нойр ханаагүй бол толгойгоо хүйтэн усаар шавшвал салтаан дээр жаахан ус дусаасан юм шиг л сайхан болоод явчихна. Ф-фу-у! Одоо ч лав цадталаа унтахгүй биз – гэж Сэм хэлэв.

Тэднийг Фарамирын дэргэд арьсаар бүтээсэн торхон дээр суулгахад хүмүүсийн сууж байгаа сандлаас хавьгүй өндөр суудал болжээ. Гэнэт бүгдээрээ босч, баруун зүг харан нэг минут орчим дуугүй зогсов. Фарамир хоббитуудыг ч гэсэн бос гэсэн дохио өгөв.

- Хоолны өмнө бид сөнөсөн Нуменор руу, цааш нь үржил шимтэй хэвээр орхигдсон Буянт хязгаар руу, бүр цааш нь мөнх цагийн өмнөх эх орон руугаа хардаг юм. Танайд ийм заншил байхгүй юу? – гэж Фарамир суухдаа асуув.

- Үгүй ээ, - гэж өөрийгөө юм мэдэхгүй бүдүүлэг толгой хэмээн дотроо зэмлэсэн Фродо хэлээд: - Гэвч айлд зочлуулахдаа хоолны өмнө гэрийн эзэнд мэхийж ёсолж талархал илэрхийлдэг

- Манайд ч гэсэн ийм заншил бий.

Олон хоног хагас өлөн, хүйтэн, шавар намаг дундуур алхсан хоббитуудад оройн хоол найр шиг санагдлаа. Алтлаг өнгөтэй, сэрүүхэн, анхилуун үнэрт дарс, цөцгийтэй талх, хатаасан жимс, шинэхэн бяслаг, дээр нь бас цэвэрхэн таваг, халбага, сэрээ! Фродо, Сэм хоёр өгсөн болгоныг тэр доор нь явуулж орхиод, нэмүүлэхээс татгалзсангүй, дараа дахин нэг нэмүүлэв. Дарс Кветлориэнээс хойш анх удаа сэтгэл санааг нь өөд татав.

Хоолны дараа Фарамир тэр хоёрыг хагас хөшиг татсан нэг буланд аваачлаа. Тийш нь буйдан сандал, хоёр жижиг сандал авчрав. Буланд шавар дэнлүү асч байлаа.

- Одоохон та хоёрын нойр хүрнэ. Ялангуяа оройн хоол хүртэл нүдээ аниагүй эрхэм хүндэт Сэммиум. Нэг бол өөрийнхөө өлөн ходоодыг, нэг бол эзнээ надаас хамгаалсан байх. Гэвч их идсэний дараа, ялангуяа хоол идэлгүй удсаны дараа гэнэт их идсэний дараа нойрыг давсан нь дээр. Жаахан ярилцъя. Та хоёрт Уудам хөндийн орноос нааш аялсан тухайгаа ярих юм бий. Бас хувь заяанд хөөгдөн ирсэн орныхоо тухай мэдэхэд илүүдэхгүй. Надад миний ах Боромир, өвгөн шидтэн Митрандир, Лориэний гайхамшигт ардуудын тухай ярьж өгөөч.

Фродогийн нойр хулжсан боловч тэр ярих тун ч дургүй байлаа. Сайхан хоол, сайн дарс түүний хэлийг загатнуулаад байсан тул ямар ч гэсэн загатнааг нь гаргахаар шийджээ. Сэм сайхан сэтгэлээр гэрэлтэж, аман дотроо дуу аялж байсан бөгөөд эхэн үед Фродогийн ярихыг сонсон толгойгоо нэлээд лав лав дохиж суулаа.

Фродо зөвхөн бөгжний тухай нэг ч үг дурсалгүйгээр олон зүйл ярив. Боромирын эрэлхэг баатарлагийг бахдан Бөглүүд ойд чонодолоохуудтай тулалдахад, Карадрасын цасанд, Гэндальфийн амь үрэгдсэн Мориин хонгилуудад хэрхэн тулалдсаныг ярив. Гүүрэн дээр болсон тулалдаан Фарамирын анхаарлыг татлаа.

- Боромирын хувьд орхуудаас зугтах гэдэг түүний зан биш, тэр Барлог гэдэг галзуу мангасаас бусдыгаа хамгаалан ганцаараа тулалдаад хамгийн сүүлд орно гэдэг бол харин түүний зан мөн дөө.

- Тэр хамгийн сүүлд явж байсан юм. Арагорн түрүүлж явсан. Гэндальфаас гадна ганцхан тэр л зам мэддэг. Хэрэв бид байгаагүй бол тэр ч, Боромир ч эргэж гүйх хэрэг байгаагүй.

- Тэр минь Митрандиртай хамт тулалдаад амьүүрэгдсэн бол Рэросын хүрхрээний дэргэдэх хорон үхлээс зайлах байж дээ.

- Магадгүй л юм. Гэвч чи амласан ёсоороо өөрийнхөө ард түмний түүхийг яриач дээ – хэмээн Фродо ярианыхаа аюултай эргэлтээс зайлсхийхийн тулд дахин буллав:

- Би Минас-Итиль, Осгилиатын тухай, авгагдашгүй Минас-Тиритийн тухай сонсмоор байна. Энэ дайнд тэсч чадна гэсэн найдвар байна уу?

- Найдвар бий юу гэж асууж байна уу? Бидэнд аль эрт ямар ч найдвар байхгүй болсон. Үнэхээр Элендилийн илд дахин гялалзах юм бол бидний зүрхэнд найдвар гэрэлтэнэ, бидний сүйрлийн өдөр цаашилна, гэхдээ тийм удаан биш. Эльфүүдээс ч юм уу, хүмүүсээс урьд өмнө байгаагүй өөр тусламж ирэхгүй л болов уу. Дайсны хүч улам л нэмэгдээд, бидний хүч улам л сулраад байна. Манай ард түмэн гундаж байна, энэ намрын дараа хавар гэж байхгүй биз дээ. Нэгэн цагт нуменорчууд тэнгисийн эрэг хавийн бүх газар, бүр эх газарт ч нутаглаж байсан юм. Гэвч хар шид тэдний гүрнийг идчихсэн юм даа. Нэг хэсэг нь хар хорын үйлд авгаж, ид шидэнд идэгдэж, нөгөө хэсэг нь хоосон цэнгэл, тансаг хэрэглээний боол болж, гурав дахь хэсэг нь өөр хоорондоо байлдсаар дайсны идэш болсон.

Гондор хар шидийн салхинаас тойрч гарсан. Дайсанг бид хэзээ ч хүндэлж байгаагүй. Эрт цагаас мэргэн ухаан, бардам гоо сайхан, өрнийн баялаг, Сайхан Элендилийн удмын хаадуудын улсуудаар алдаршиж ирсэн. Гэвч хожим нь тэр бардам ихэмсэг зан нь Гондорыг сүйтгэсэн юм. Эзэн хаад нь ихэмсэг бардам мөртөө мэргэн ухаан дутсанаас Дайсан үүрд устсан гэж бодсоор байх хугацаанд дутуу алуулсан хорт могой сэргэчихсэн юм.

Арван хоёр дахь эзэн захирагч Кирионы үед (миний эцэг хорин зургаа дахь нь) Гондорчууд бидэнд туслахаар ирж, Келебрантын аймшигт тулалдаанд хойноос орж ирсэн дайснуудыг бутцохисон юм. Бид тэднийг мустангримчууд, адуучид гэж нэрлэдэг. Тэгээд эзэнгүй байсан Клендархоны зэлүүд талыг тэдэнд бэлэглэсэн юм. Тэр цагаас хойш Ристани гэж нэрлэдэг болсон. Тэд манай үнэнч холбоотон болж, нэг бус удаа бидэнд туслахаар ирж байсан, манай умард хязгаарыг хамгаалалтдаа авсан.

Ристаничууд бидэнд их тааладдаг. Өндөр чилгэр эрчүүд, эрчүүдээсээ дутахааргүй эрэлхэг зоригтой, чийрэг чанга, алтлаг үстэй, гоолиг, тунгалаг нүдэн бүсгүйчүүд. Тэд хүн төрөлхтний залуу цагийг бидэнд санагдуулдаг юм.

Харин одоо мустангримчүүд олон талаар бидэнтэй адилссан. Ааш араншин нь зөөлөрсөн, гар урлал нь урлаг болсон, бид ч гэсэн тэдэнтэй адилссан. Бид мустангримчүүдийн адилаар баатарлаг гавьяа, тулааны урлагийг бүхнээс өндөр үнэлдэг, өнөө цагийн дайчин олон зүйлийг мэддэг, чаддаг байх ёстой. Тиймээс гарамгай дайчдыг манайд онцгой их хүндэлдэг. Миний ах Боромир тийм л хүн байсан. Асар их чадварлаг, эрэмгий баатар ван, тэр Гондортоо хамгийн хүндтэй хүн байсан юм. Хаан ширээг залгамжлагчдын дотор түүнтэй эгнэх хэн ч байгаагүй. Тэгээд их бүрээ нь анх удаа л тэгж чанга цууриалсан юм даа.

Фарамир санаа алдаад дуугүй болов.

- Та эльфүүдийн тухай яагаад ярьсангүй вэ? – гэж Сэм зориг гарган асуув. Фарамир эльфүүдэд их элэгсэг ханддагийг нь тэр анзаарсан бөгөөд энэ нь түүний найрсаг, эелдэг зан, амтат хоол, сайхан дарснаас илүүгээр сэрдлэгийг нь дарж байв.

- Чиний зөв өө, ноён Сэм. Гэхдээ би эльфүүдийн тухай их юм мэдэхгүй. Чи Митрандиртай хамт явж байсан болохоор Элрондтой уулзаж ярилцсан байлгүй. Нуменорчуудын өвөг дээдэс эданчууд эльфүүдтэй мөр зэрэгцэн тулалдаж явсан бөгөөд үүнийхээ шанд Буянт хязгаарын ойролцоо, тэнгисийн дундах газарт суурьшсан юм гэнэлээ. Гэвч Дундад газарт харанхуй нөмрөхөд Дайсны явуулгаар хүмүүс эльфүүдээс холдсон, цаг улирах тусам улам холдсоор өөр өөр замаар орсон юм даа. Одоо хүмүүс эльфүүдээс айдаг, тэдэнд итгэдэггүй, тэгсэн мөртөө тэдний тухай бараг юу ч мэдэхгүй шүү дээ. Тэгээд бүгдээрээ адилхан хар эзний заналт дайснууд мөртөө эльфүүдийн тухай Алтан ойн шид гэхчлэн аймшигтай үлгэрүүд зохиож ярьдаг юм.

Гэхдээ л бидний дунд эльфүүдтэй найзалдаг хүмүүс мэр сэр байдаг, нууцаар Лориэн ордог боловч эргэж ирэх нь цөөн. Би тэдний нэг л дээ. Одоо цагт анхдагч төрлийнхөнтэй хүмүүс холбогдох аюултай гэж би боддог юм. Гэвч би чамд атаархаж байна. Чи Цагаан хатан хаантай уулзаж ярилцсан шүү дээ.

- Лориэний хатан хаан! Галадриэль! - хэмээн Сэм дуу алдаад:

- Ээ дээ, та түүнийг харсан ч болоосой, нүд салгах аргагүй. Би ердийн л нэг хоббит, зүгээр л нэг цэцэрлэгч, танаас дээгүүр харайна гэж байхгүй. Би шүлэг зохиож чадахгүй, яахав заримдаа инээдэмтэй, хөгжилтэй ч юм уу дуурхуу юм зохиодог л юм. Би хатан хааны тухай ярьж чадахгүй, түүний тухай ярьж гэвэл дуулах хэрэгтэй. Харин тэнэмэл, яагаав Арагорн, бас өвгөн ноён Бильбо бол чадна. Гэлээ ч гэсэн түүний тухай дуулмаар санагддаг юм. Мөн ч онцгой доо, ноён минь! Хараад ханашгүй! Нэг харахад цэцэглэж байгаа гоолигхон мод шиг, нэг харахад цагаахан амариллис цэцгийн дэлбээг сэвшээ салхи үлээж байгаа юм шиг, дахиад нэг харахад сарны туяанаас ч зөөлөн энхрий, нарнаас ч дулаахан, тэгсэн мөртөө одтой шөнийн хүйтэн шиг! Бардам, цасанд хучигдсан уул шиг ихэмсэг, үсэндээ цэцгэн эрих зүүсэн жаахан охин шиг хөгжилтэйхөн. Ер нь би ярьж чадахгүй нь ээ.

- Үнэхээр сайхан гэдэг нь илт байна аа. Гэхдээ энэ бол мөхлийн гоо сайхан.

- Би тэгж хэлмээргүй байна, миний бодлоор бол, хүмүүс өөрийнхөө мөхлийг өөртөө тээж явдаг, тэгээд тэрнийгээ Кветлориэнд аваачихаад “Хаанаас гараад ирэв?” гэж гайхдаг. “Илбэдсэнээс зайлахгүй” гэж боддог. За яахав, мөхлийнх байг гэж бодъё, тэгвэл юуных нь гоо сайхан байхав дээ! Түүний төлөө чиний хөлөг онгоц хад мөргөж байгаа юм шиг бут үсэрч болно, эсвэл хоббит голд живж байгаа юм шиг живж болно. Гэвч үүнд хад ч, гол ч буруугүй, тийм биз дээ? Боро... – гэснээ Сэмийн царай улайж түгдрэв.

- Тийм үү? “Боромир” – гээд юу хэлэх гэсэн юм бэ? Гүйцээж хэл, тэр бас мөхлөө өөрөө тээж аваачсан юм уу?

- За өршөөгөөрэй ноёнтоон, баатрын хувьд ёстой баатар, тэр талаар хэлэх юм байхгүй. Гэвч та ерөнхийд нь таамаглаж байна. Би бүр Уудам хөндийгөөс эхлээд л Боромироос нүд

салгахгүй байсан. Муу санаа байхгүй, би чинь эзнээ хамгаалах хэрэгтэй шүү дээ. Танд гэж хэлэхэд тэр Лориэнд миний түрүүнд дурдсан зүйлийг харсан, тэгээд юу хүсч байгаагаа ойлгосон. Тэр бүр эхнээсээ л Дайсны бөгжийг өөрийн болгохыг хүссэн юм!

- Сэм! – хэмээн Фродо айдас дүүрэн дуу алдав. Тэр Сэмийн яриаг анзааралгүй бодолдоо автаж байгаад өнгөрсөн хойно анзаарчээ.

- Эцэг минь! - гэж Сэм уулга алдаад, царай нь хана шиг цайснаа намуу шиг улайв:

- Дахиад л үг алдчихлаа! “Чи наад онгорхойгоо хөлөөрөө бөглөчихвөл таарна” гэж миний Жихарь хэдэн ч удаа хэллээ дээ. Үнэн л юм хэлж байж. Лоольтой лууван чи юугаа донгосох нь энэ вэ! Ноёнтон минь намайг сонс! – хэмээн тэр хамаг зоригоо шавхан байж дахин Фарамирт хандаж:

- Та зарц нь усан тэнэг байсны төлөө эзнийг минь гомдоох эрхгүй шүү. Та их гоё ярьсан, ялангуяа эльфүүдийн тухай. Тэгээд л би чихээ дэлдийлгэж, амаа ангайлгачихлаа. Үгээр өмд ч эсгэж болно гэдэг биз дээ. Та өөрийгөө үйл хэргээр л харуулаарай – гээд тавьчихав.

- Тэгэх л хэрэгтэй боллоо доо - хэмээн Фарамир нэг л хачин инээмсэглэн аяархан хэлээд:

- Ингээд бүх оньсогны хариу нэгмөсөн олдох шив дээ! Бүгдийг захирагч бөгж Дундад газраас үүрд алга болсон! Боромир түүнийг авахыг оролдсон, та нар зугтаж гарсан, тийм үү? Зугтааж зугтааж эцэст нь над дээр гүйгээд ирсэн! Орхигдсон орон, хоёр жижиг биет, миний дайчид, гарын доор бүгдийг захирагч бөгж! Тэгэхээр Гондорын жанжин Фарамир өөрийгөө үйл хэргээр харуул даа! Ха! – гээд тэр сунайтал босч, ширүүн, захирангуй төрх нь тодорч, саарал нүд нь гялалзав.

Фродо, Сэм хоёр сандал дээрээс зэрэг ухасхийн босч, хана налан зэрэгцэж зогсоод илдээ тэмтэрцгээв. Агуйд гэнэт нам гүм болж, бүгд тэдэн рүү гайхан харж байв. Гэвч Фарамир суудалдаа суугаад, чимээгүйхэн инээснээ царай нь дахин барайв.

- Хөөрхий Боромир! Ямар хүнд сорилт вэ! Алс газрын хоёр аянч та хоёр хөнөөлт ачаагаа үүрээд надад ямар их уй гашуу авчрав аа! Гэхдээ би та нар хүмүүсийн тухай бодлогоос илүү үнэхээр жижиг биетүүдийн тухай бодож байна. Гондорчууд бид ямагт үнэнийг ярьдаг. Онгирох нь их ховор ч гэсэн онгирлоо гэхэд хэлсэн үгнээсээ хэрхэвч буцдаггүй. “Би энэ зангиаг их зам дээр хэвтэж байсан ч авахгүй байсан” гэж би хэлсэн. Би одоо түүнийг авахсан гэж тэсч ядаж байсан ч миний хэлсэн үг андгай, андгайг зөрчиж болохгүй.

Гэхдээ би түүнийг авахсан гэж тэсч ядаагүй байна. Яагаад гэвэл зарим үхлээс эргэж харалгүй зугтаах хэрэгтэй гэдгийг багтай мэдэж байгаа учраас ингэж байж магадгүй. Тайвширцгаа. Харин чи, Сэм, үг алдсан боловч энэ бол хувь тавилангийн дуу хоолой байсан юм. Чамд үнэнч бөгөөд зөнч зүрх байна. Тэр чинь чиний нүднээс соргог. Энэ дуу ч гэсэн зүрх чинь чамайг хөөдсөнгүй. Чи хамгаас хайртай эзэндээ их тус хүргэсэн ч байж магадгүй. Би эзний чинь төлөө чадах бүхнээ хийнэ. Тайвшир даа. Харин хойшид тэр үгийг хэлэхээс болгоомжил. Нэг үг алдахад бүх юмаа алдаж болно шүү.

Хоббитууд дахин сандал дээр сууж, хүмүүс ууж дуусаагүй дарсаа гүйцээн ууж, яриагаа үргэлжлүүлэв.

- За, Фродо, одоо бид хоёр бие биеэ ойлголоо. Хэрэв чи энэ ачааг үүрэх дургүй байсан ч бусдын гуйлтыг буцааж чадалгүй үүрсэн бол би чамайг өрөвдөж байна. Би чамайг гайхан биширч байна. Чи түүний хэмжээлгүй их хүчийг ашиглах гэж оролдох ч үгүй байна шүү дээ. Та хоёр надад шинэ ертөнц нээж өглөө. Танайхан бүгдээрээ ийм гэж үү? Танай орон амар амгалан, элбэг хангалуун, цэцэрлэгчид их хүндтэй байдаг байх аа – гэж Фарамир хэлэв.

- Манайд бүх юм сайн сайхан биш ээ, гэхдээ цэцэрлэгчид их хүндтэй байдаг шүү - гэж Фродо хариулав.

- Гэхдээ та нар цэцэрлэгтээ ч гэсэн заримдаа ядардаг биз дээ, наран доорх бүх амьтны заяа ийм. Энд та нар орон гэрээсээ хол, аян замд туйлдаж ядарсан. Өнөөдөртөө ингээд болно. Хоёулаа тайван унтацгаа, нойр чинь сайн хүрэх болтугай. Айж эмээх юм юу ч байхгүй! Би түүнийг харах ч хүсэл алга, барих ч хүсэл алга, түүний тухай өөр юм мэдэхийг ч хүсэхгүй. Дэндүү ихийг мэдэж авлаа. Би Дрогогийн хүү Фродогоос сул дорой хэнд ч гэсэн үхэл мөхөл авчрах тэр аюулаас хол байхыг хүсч байна. Явж амарцгаа, гэхдээ эхлээд хаашаа явж байгаа, ямар бодолтой байгаагаа хэлэхгүй юм уу? Яагаад гэвэл тандаж, тооцоолж, бодох хэрэгтэй. Цаг яваад л байгаа шүү. Бид өглөө сална, өөр өөрийн замаар явна.

Фродо айж эмээхээ больсон ч биеэ барьж чадалгүй чичирч байв. Гэвч ихэд ядарсан тул зөрүүдэлж, аргалаад өнгөрөхийг бодсонгүй.

- Би Мордор руу орох зам хайж байсан юм. Горгорот хүрээд, Галт уулын тогоо руу түүнийг шидэх гэсэн юм. Гэндальф тэгж тушаасан. Тэнд хүрч чадахгүй л юм шиг байна даа.

Фарамир түүний өөдөөс мэл гайхан ширтэв. Тэгээд Фродо найган унахад эвгэйхэн барьж аваад, гар дээрээ өргөн оронд хэвтүүлж, дулаахан хучив. Фродо үхсэн мэт унтлаа. Дэргэд нь Сэмд ор засчээ. Сэм жаахан бодож байснаа гүнээ мэхийв.

- Сайхан нойрсоорой, ноёнтоон. Та өөрийгөө үйл хэргээр харууллаа.

- Харуулсан уу? - гэж Фарамир асуув.

- Тиймээ, эзэнтээн, их сайн харуулсан. Ярих юм байхгүй.

Фарамир инээмсгэлэв.

- Зарцад ахдахаар зоригтой ярьдаг юм байна чи, ноён Сэм. Би тоглож байна аа. Өөрөө магтуулах гавьяатай хүнээс магтаал сонсох дээдийн шагнал. Гэхдээ би магтаал сонсох гавьяа байгуулаагүй, яагаад гэвэл өөрөөр үйлдэх шалтгаан надад байгаагүй.

- Та манай эзнийг эльфтэй адилхан гэж хэлснээ санаж байна уу, тэр үнэн шүү. Харин та өөрөө... - гээд Сэм түгдэрснээ: - Шидтэнтэй, Гэндальфтай адилхан юм байна.

- Тийм бий, Нуменорын цусных байж болох л юм. Сайхан нойрсоорой!

Бүлэг 16

Хориотой цөөрөм

Фродо нүдээ нээтэл дээрээс нь Фарамир бөхийж байгааг үзээд айсандаа ухасхийн зайллаа.

- Айх хэрэггүй – гэж Фарамир түүнийг тайвшруулав.

- Өглөө болчихсон уу? – хэмээн Фродо эвшээхэд:

- Хараахан болоогүй, гэвч үүр цайх дөхөж байна. Одоо тэргэл сартай байгаа шүү дээ, гарч харах уу? Бас чамтай зөвлөлдөх бага сага юм байна. Чамайг сэрээхгүй юмсан гэж их бодлоо. Гарах уу?

- Гаръя – гээд Фродо хөнжил болон дээр нь тавьсан барын арьснаас сугаран гарангуутаа даарав. Гал түлээгүй агуйд хүйт хургажээ. Шөнийн нам гүмийг хүрхрээний чимээ эвдэж байлаа. Тэр цуваа өмсөөд Фарамирын араас дагав.

Сэм түлхсэн юм шиг сэрээд эзнийхээ ор дэр хоосон байгааг харангуут үсрэн босов. Нуман хаалгаар өндөр, нам хоёр дүрс гарч яваа нь харагдахад тэр араас нь ухасхийн хананы дагуу сүрэл дээр унтаж байгаа хүмүүсийн хоорондуур нөгөө хоёрын араас яарав. Усан хөшиг сарны туяанд торгомсог, мөнгөлөг сувдан өнгөөр гялалзан байлаа. Түүнийг сонирхох зав байсангүй. Хажуугийн хаалгаар эзнийхээ араас ухасхийв. Хаалганы цаанаас гулсамхай саарал шаталсан гишгүүр эхэлж, мөддөө дуусах шинжгүй. Эцэст нь тэд гүнзгий чулуун худагны ёроолд өгсөн гарч, тээр дээр тэнгэрийн цайвар хэлтэрхий харагдав. Тэндээс хоёр шат салаалсан байх бөгөөд нэг нь чигээрээ өндөр эрэг өөд гарсан бололтой, нөгөө нь зүүн тийш эргэжээ. Зүүн шатаар эргэхэд шат цамхгийн шат мэт мушгиран өгсчээ.

Харанхуйгаас хясааны орой дээрх уудам талбайд гарч ирэв. Баруун талаас нь ус олгойдон гарч, хясааны ирмэгээс хүрхрэн бууж, хөөсрөн оволзсоор тэдний эгц доор буугаад, тэдний зүүн гар талаар зүүнээс баруун тийш толигор засмал голдрилоо даган урсчээ. Хясааны ирмэг дээр харуул зогсоод доош ширтэж байв.

Фродо тосорхог хар урсгал хэрхэн бүжиглэн оволзож байгааг харж байснаа алсыг харав. Хөрсөн газар өглөөг хүлээн нам гүмхэн байв. Дүгрэг цагаан сар баруун тийш хэвийжээ. Уудам хөндийд манан хөшиглөж, доогуур нь Андуин мөрөн чимээгүй гулсч харагдана. Цаад талд нь Гондорын цасан цагаан уулс Эред-Нимрайсын шовх оргилууд харанхуйг цоолон босчээ.

Фродо тийш харан чичрэн зогсохдоо хамтрагчид маань шөнийн энэ хязгааргүй уудмын хаана нь байгаа бол доо хэмээн бодож байв. Тэд маань явж байгаа болов уу, унтаж байна уу, эсвэл хөшсөн бие нь мананд өлгөйдүүлсэн болов уу? Яах гэж энд дагуулж ирсэн юм бол гэж бодохгүй унтаж байхад ямар сайхан байв аа.

Сэм ч тэр хоёрыг яах гэж энд ирснийг ойлгосонгүй, зориуд эзнийхээ чихэнд сонсох гэж:

- Сайхан юм аа эзэн минь, ярих юм алга. Харин жаахан хүйтэн байна, хөлдчихгүй юмсан – гэхэд түүний үгийг Фродо биш, Фарамир сонсжээ:

- Сар Гондорын дээгүүр жаргаж байна. Сайхан Итил Дундад газрыг орхихдоо мөнгөн үст Миндоллуиныг салалтын харцаар энхрийлж байна. Жаахан даарахад харамсах юм байхгүй. Гэхдээ би үүнийг харуулах гэж эзнийг чинь авчраагүй. Харин Сэммиум чамайг би дуудаагүй, чи өөрийнхөө сонор сэрэмжийн төлөөсийг төлж байна. Зүгээр зүгээр, дарс балгаад бүлээцчихнэ. Явцгаая, би та хоёрт бага сага юм үзүүлье!

Тэр хар хясаан дээр хөшөө мэт зогсч байгаа харуулын дэргэд очиход Фродо хоцролгүй дагаж, Сэм араас нь даган гэлдрэв. Түүнд халтиргаатай өндөр хясаан дээгүүр явах тун эвгүй байлаа. Фарамир Фродод доошоо хар гэж заав. Хөөсрхөг мандалт нуураас эх авсан урсгал гүнзгий, дүгрэг усан санг дүүргэн эргэлдээд, тэндээс хөөс цацлан доошилжээ. Сар хүрхрээний хөлийг ташуу гэрэлтүүлж байв. Төдөлгүй Фродо усан сангийн наад эрэг дээр жижигхэн хар дүрс байгааг олж харав. Гэвч тэр дүрс өөрийг нь харж байгааг мэдэрсэн юм шиг эргэлдсэн бараан ус руу шумбаж, усны мандлыг долоолгож шидсэн чулуу мэт зүсэн алга болов. Фарамир харуул руу эргэж хараад:

- Одоо чи юу гэмээр байна, Анборн? Хэрэм үү, эсвэл үржүүлгийн амьтан уу? Бөглүүд ойн цөөрмүүдэд хар хэрмийг яаж үржүүлдэг юм бэ?

- Ямар амьтныг бүү мэд, ямар ч гэсэн шувуу биш. Дөрвөн мөчөөрөө хүн шиг сэлдэг, тун ч гавшгай сэлдэг гэж хэлэх хэрэгтэй. Түүнд энд юу хэрэгтэй юм бол? Манай хөшгөн доогуур шургах нүх хайж байгаа юм болов уу? Дайснууд манайх руу дөхөж байгаа юм шиг байна даа. Надад нум сум байна, би бас цөөрмийн эргэн тойронд дөрвөн харуул тавьсан, надаас нэг их дутахгүй харвана. Шууд харвачих уу?

- Харвах уу? - гэж Фарамир Фродо руу хялсхийн эргэж асуув. Фродо хариулалгүй түгдрэв. Тэгснээ:

- Хэрэггүй. Хэрэггүй! Хичээнгүйлэн гуйя, түүнийг битгий харва!

Сэм “харва” гэж хурдхан, чангахан хэлэх хэрэгтэй байтал хэлж чадсангүй. Тэр юу ч хараагүй боловч юуны тухай яриа болж байгаа нь тодорхой байлаа.

- Тэгэхлээр энэ юун амьтан болохыг мэдэж байгаа юм шив дээ? Тэгвэл ямар учраас тэрнийг өршөөж байгаагаа хэл. Чи яагаад ч юм өөрийнхөө төөрсөн дагуулын тухай нэг ч үг дурсаагүй. Би чамаас асууж шалгаагаагүй, зүгээр л тэрнийг бариад ир гэж тушаасан юм. Хамгийн сайн анчдаа явуулсан, гэвч тэд тэрнийг алдчихсан, ганц Анборн л тэрнийг бүрэнхийд харсан байна. Тэр их хүнд ялтай. Ууланд яах гэж молтогчин барьж байсан бэ? Тэр Хеннет-Аннунд нэвтэрсэн байна, үүнийг амиараа төлдөг юм. Би их гайхаж байна. Ийм айхтар гавшгай, зальтай, шууд манай цонхны доор тонгочиж байна. Магадгүй тэр хүмүүсийг шөнө унтдаг, юм үздэггүй гэж бодож байгаа юм уу? Юундаа тэр ингэж их сандраад байгаа юм бэ?

- Энэ асуултанд бүхэл бүтэн хоёр хариулт бий. Нэгдүгээрт, тэр хүмүүсийг бага мэднэ, тэр хичнээн зальтай байсан ч танай хуаран тэрэнд яагаад ч мэдэгдэхээргүй нууц. Хоёрдугаарт,

Тэр наашаа тэсэхийн аргагүй тэмүүлж байгаа учраас айж сэрэмжлэхээ мартсан байна.

- Тэмүүлж байгаа гэж хэлэв үү? Тэгвэл чиний тэр хүнд ачааны чинь тухай таамагласан юм биш биз?

- Тэр миний ачааны тухай мэднэ. Тэр өөрөө түүнийг олон жил тээж явсан юм.

- Тэр тээж явсан гэнэ ээ? Би бүх оньсого ард хоцорсон гэж бодсон юмсан. Тэгэхлээр тэр түүний хойноос хөөж яваа хэрэг үү?

- Хараанаасаа алдахгүй байхыг хичээж байгаа. Тэр түүнийг “эрдэнэ минь” гэж нэрлэдэг юм. Гэхдээ яг одоо бол тэр түүн рүү тэмүүлээгүй

- Тэгвэл тэрэнд юу хэрэгтэй юм бэ?

- Загас, харахгүй юу!

Тэд харанхуй цөөрөм рүү дахин харав. Хар толгой цөөрмийн цаад талаас, хясааны ёроолд шомбосхийн гарч ирэв. Мөнгөлөг өнгөөр жижиг юм гялсхийгээд, усны мандалд зөөлөн долгио тарснаа ер бусын гавшгай мэлхий дүрстэн уснаас эрэг дээр үсрэн гарч суугаад, сарны гэрэлд мөнгөлөг дүрс дахин гялсхийснээ хар дүрс мөнгөлөг зүйлд шүдээ шигтгэн зулгаж харагдав. Сар хясааны цаагуур далд орлоо.

Фарамир аяархан инээв:

- Загас! Тэгвэл ч тийм их аюултай биш ээ. Гэхдээ Хеннет-Аннуны цөөрмөөс барьсан загас ч өндөр үнэтэй дээ.

- Би онилчихсон байна, харвах юм уу, яах юм бэ? Манайх урилгагүй зочинд ганцхан шийтгэл оноодог - үхэл – гэж Анборн хэлэв

- Хүлээ, Анборн – гэж Фарамир хэлээд: - Энэ удаад бүх зүйл тийм хялбархан биш байна. Юу гэмээр байна даа, Фродо? Яагаад тэрнийг өршөөх гэж?

- Энэ бол хөөрхийлөлтэй өлсгөлөн амьтан. Тэр өөрт нь ямар аюул нүүрлэж байгааг мэдэхгүй. Гэндальф – танай Митрандир ч гэсэн тэрнийг алж болохгүй гэж хэлэх байсан, гэхдээ өөр шалтгаанаар. Тэр эльфүүдээс хүртэл түүнийг битгий ал гэж гуйж байсан. Би ямар учраас гэдгийг мэдээгүй, харин өөрийнхөө таамаглалыг хэлэхээ больё. Ямар ч гэсэн энэ амьтан миний даалгаварт хамаатай. Чи биднийг олохоос өмнө тэр бид хоёрт замчилж байсан юм.

- Замчилж явсан гэнэ ээ! Хачин хэрэг байна даа. Би чиний төлөө олон зүйл хийхэд бэлэн байна, Фродо. Гэхдээ энэ арай хэтэрнэ ээ. Зальт новшийг юу ч болоогүй юм шиг тавиад явуулах гэж үү? Та нарт наалдуулахын тулд уу? Эсвэл орхуудад баригдаад долоон булчирхайгаа тоочуулах гэж үү? Үгүй ээ, тэрнийг алах хэрэгтэй, ядаж барих хэрэгтэй. Нэн даруй барих юм уу алах. Гэвч энэ бузар новшийг өдөт сумнаас өөр юу гүйцэх юм бэ?

- Би тэрэн рүү чимээгүйхэн буугаад очъё. Нумаа онилж бай. Хэрэв би тэрнийг алдчихвал

намайг харвачихаарай. Би зугатаахгүй.

- Яв яв, хурдал! - гэж Фарамир хэлээд: - Хэрэв тэрний аз болж амьд үлдвэл үхэх хүртлээ чиний үнэнч боол болог. Анборн, Фродог эрэгт хүргээд өг, нум сумаа нааш нь өгчих, болгоомжтой яваарай, тэрний нүд чих хоёр дэндүү гарамгай юм байна.

Анборн амандаа нэг юм дургүйцэн үглээд Фродог дагуулан эргүүлгэн шатаар доош бууж талбай хүрээд, тэндээс нөгөө шатаар дээш өгсөн бутан дунд нуугдсан нарийхан ангалаас гарч, цөөрмийн өмнөд өндөр эрэг дээр гарав. Харанхуйд зөвхөн сарны сүүлчийн бүдэг туяанд сааралтан байлаа. Хорлум үзэгдэхгүй болжээ. Фродо хэдэн алхам урагшлахад Анборн араас нь чимээ гаргалгүй дагав.

- Яв! Баруун талд эгц эрэг байна. Цөөрөмд унавал чиний найз загасчнаас өөр хэн ч чамайг аварч чадахгүй. Харин зугатах гэж бодсоны ч хэрэггүй шүү. Чамд харагдахгүй байгаа ч гэсэн эргэн тойронд чинь харваачид байгаа – гэж Анборн Фродогийн чихэнд шивнэв.

Фродо хорлум маягаар дөрвөн хөллөн хадан эргийг сөөм сөөмөөр тэмтрэн мөлхөв. Чулуун жим тэгшхэн боловч гөлгөр, халтирамхай байлаа. Тэр мөлхөхөө болиод чагнав. Эхлээд зөвхөн ар талд хүрхрээ шуугиж байсан бол сүүлдээ хажууханд нь сөөнгө хоолойгоор шивнэхийг сонслоо:

- Загас, сайхан загас. Цагаан хоншоор алга болсон, эрдэнэ минь, тиймээ арайхийж алга боллоо. Тиймм шшшүү. Загасаа тайван идэжжж болно, үгүй ээ, тайван бишшш. Бидний эрдэнийг аваад явсан. Хогийн муу хоббитууд, новшийн хоббитууд. Биднийг хаяссан, хорлум, эрдэнийг минь аваад явсан. Ганцхан хөөрхий Смеагорл үлдсэн, хорлум. Эрдэнэ байхгүй. Муу хүмүүс миний эрдэнийг хулгайлахыг хүсч байна. Хараал идсэн хулгайч нар! Загас, амттайхан загас. Бид хооллож аваад бүхнээс хүчтэй болно. Хурц нүд, бяртай чанга гар-ссс. Бид багалзуурдана, эрдэнэ минь. Бид бүгдийг нь багалзуурдана. Амттайхан загас. Ссайхан загас!

Тэр ийнхүү хүрхрээний чимээ мэт тасралтгүй үглэх бөгөөд хажуугаар нь шал шалхийтэлажилж, хуухирч, гүд гүд залгих сонсдоно. Фродо түүнийг өрөвдсөн, ой гутсандаа бараг уйлмаар болов. Ядаж дуугүй болоод өгөөсэй, ийм чимээ дахиад хэзээ ч сонсохгүй байх юмсан хэмээн бодож байж ядан хэвтэв. Анборн тав зургаахан алхмын цаана байгаа. Түүн рүү мөлхөж очоод тэрнийг харвачих гэж хэлмээр л байлаа. Хорлумыг загас гударч байх хооронд харуулууд улаан дэргэд нь ирчихээд байлаа. Ганцхан мэргэн сум нисэхэд л Фродо энэ гутамшигт чимээг сонсохоо болих билээ. Гэвч болохгүй, болохгүй, Хорлум түүнд найдах эрхтэй. Зарц нь эзэндээ найдаж, эзнээрээ хамгаалуулах эрхтэй. Хорлум байгаагүй бол Сэм бид хоёр Үхдлүүдийн намагт живэх байсан. Гэндальф байсан бол тэрнийг алуулахгүй байсан гэдгийг Фродо зөнгөөрөө мэдэж байлаа.

- Смеагорл! - гэж аяархан дуудав.

- Загас, амттайхан загас - хэмээн сөөнгөтөнө.

- Смеагорл! – гэж чангахан дуудтал тэр чимээгүй болов.

- Смеагорл, эзэн чамайг хайж байна. Эзэн ирлээ. Нааш ир, Смеагорл!

Хариу байдаггүй, шүднийхээ завсраар агаар сорох мэт аяархан исгэрэх нь дуулдав.

- Нааш ир, Смеагорл! Наана чинь аюултай, хүмүүс чамайг олбол ална. Амьд үлдье гэвэл хурдан хүрээд ир. Эзэндээ хүрээд ир!

- Үгүй! Муухай эзэн. Хөөрхий Смеагорлыг хөсөр хаяад шинэ найз нартай болсон. Эзэн хүлээж л байг. Смеагорл хоолоо идэж дуусаагүй байна.

- Бидэнд цаг байхгүй. Загасаа бариад наашаа ир!

- Үгүй шшшүү! Эхлээд Смеагорл загасаа иднэ!

- Смеагорл! Эрдэнэ чинь уурлана шүү. Би эрдэнийг гартаа барьж байгаад Смеагорл загасныхаа ясанд хахаж үхэг гэж хэлнэ. Тэгээд чи хэзээ ч дахиж загас идэхгүй болно. Нааш ир, эрдэнэ чинь хүлээж байна!

Хорлум могойчлон исгэрээд харанхуй дундаас дөрвөн хөллөн давхиж ирэв. Аманд нь хагасыг нь идчихсэн загас, гарт нь нэг бүтэн загас байна. Тэр Фродод тулж ирээд, нүдэндээ цийлэн гэрэл гялалзуулан нохой шиг үнэрлэв. Дараа нь амнаасаа загасаа аваад өндийлөө.

- Сайн эзэн! Сайн хоббит хөөрхий Смеагорлдоо эргэж ирлээ. Дуулгавартай Смеагорл дуудангуут хүрээд ирлээ. Явцгаая, түргэн явцгаая. Тийм шшшүүү. хоншоорууд байхгүй байгаа дээр модон дундуур, ой дундуур явцгаая. Тийм э, хурррдан!

- Тийм ээ, бид одоохон явна, би амласан ёсоороо чамтай хамт явна. Гэхдээ яг одоо биш. Дахиад амлаж байна. Одоо аюултай. Би чамайг аварна, харин чи надад итгэх хэрэгтэй.

- Эзэнд итгэх гэж үү, яах юм бэ? Яагаад шууд явж болохгүй гэж? Нөгөө муухай ааштай, бүдүүлэг хаашаа алга болчихов? Тэр хаана нуугдсан бэ?

- Тэр дээр байгаа – гэж Фродо хүрхрээний тийш заагаад:

- Би түүнийг орхиж явахгүй. Явья, түүн дээр очъё.

Фродод их хэцүү байлаа. Хуурч байгаа юм шиг санагдаад байв. Фарамир Хорлумыг ал гэж тушаахгүй л байх, гэхдээ хүлэх нь мэдээж. Тэгвэл урваж сурсан зовлонт амьтан өөрийг нь хуурчихлаа гэж бодно. Фродо дараа нь түүний амийг аварсан гэдгээ, бас ингэхээс өөр арга байгаагүй гэдгээ яаж итгүүлэх юм бэ? Тэгээд яах вэ? Хоёр талд адилхан үйлчлэх боломжгүй ч гэсэн тэгэхээс өөр арга алга, оролдоод л үзэхээс.

- Явцгаая! Тэгэхгүй бол эрдэнэ уурлана. Бид голоор буцаж явна. Явцгаая, явцгаая!

Хорлум итгэлгүйхэн үнэрлэсээр цөөрмийн захаар мөлхөснөө зогсож толгойгоо өргөв:

- Энд хэн нэгэн байна! Хоббит биш байна - гэснээ гэнэт аргашаа үсрэв. Аяганаасаа бүлтрэх

шахсан нүд нь ногоон очоор гялалзана:

- Эзэн, эзэн! Муухай амьтан! Адгийн урвагч шшшаар!

Тэр том гэгч нулимаад, урт хуруунууд нь Фродогийн хоолой руу сарвайлаа. Араас Анборны сүрлэг том бие гарч ирээд, хүчирхэг гараараа Хорлумын өрвөгөр дэлнээс базаж, түүнийг газарт наав. Могой шиг гулсамхай, гавшгай, нойтон, муур шиг самардамтай, нохой шиг хазамхай тэр Анборны гараас бараг л мултрах дөхөв. Гэвч дахиад хоёр хүн харанхуйгаас гарч ирлээ.

- Номхон байгаарай! Одоохон хэдэн сум зоогоод зараатай адилхан болгоод өгнө шүү! – гэж тэдний нэг нь зандрав.

Хорлум нялцайн суларч, гасалж гийнав. Түүнийг чивчиртэл хүллээ.

- Болгоомжтой! Гарын чинь аяыг даахгүй шүү, наадах чинь номхорно гээд эргэж хорлумд хандан - Смеагорл! Эд нар чамайг гомдоохгүй. Би чамтай хамт явна, бүх юм сайхан болно. Би баталж байна. Эзэндээ итгэ! – гэж Фродо сандрав.

Хорлум эргэж өөдөөс нь нулимлаа. Дайчид толгойд нь хүүдий углаад авч одов. Фродо уруу царайлсаар араас нь дагалаа. Ангалаар орж, урт шатаар агуйд эргэж ирлээ. Хоёр гурван бамбар асч байна. Дайчид нойрон дундаа эргэж хөрвөөнө. Сэм түрүүлээд ирчихсэн, хүлээтэй нялцгар юмыг зэвүүрхэн харж зогсоно.

- Баригдаа шив дээ? - гэж тэр Фродогоос асуулаа.

- Энэнийг бариагүй. Би дуудсан юм, миний үгэнд итгээд өөрөө хүрч ирсэн. Битгий ийм чанга хүл гэж би хэлсэн л дээ. Бүрэн бүтэн байгаа гэж найдаж байна. Гэхдээ л надад муухай байна.

- Надад ч гэсэн. Энэ бузрын гай дуусахгүй – гэж Сэм баргар царайлан санаа алдав. Фарамир буйдан сандал дээр сууж, булангийн адарт дахин дэнлүү асаав. Тэр хоббитуудыг сандал дээр суу гэж дохив.

- Зочдод дарс авчир, олзлогдогчийг нааш нь аваад ир – гэж жанжин тушаалаа.

Дарс ч авчирлаа, дараа нь Анборн Хорлумыг чирж ирэв. Тэр түүний толгойноос хүүдийг мулталж аваад хөл дээр нь босгож, өөрөө ард нь зогсоод гараараа дэмнэж байв. Хорлум хар хорслоо хавдсан зовхиныхоо цаанаа нууж гэрэлд гялбан сохор юм шиг харагдана. Тэр даанч хэтэрхий өрөвдөлтэй харагдаж байлаа. Биенээс нь ус дусалж, загас ханхлах бөгөөд нэг гартаа загас базжээ. Шингэн өрвөгөр үс нь ясан дух руу нь унжиж, хамар доороос нь том нус унжжээ.

- Бидний хүлгийг тайл! Бидний хүлгийг тайлл! Бид өвсөж байна, муухай олс өвсгөж байна. Бид ямар ч муу юм хийгээгүй! – гэж тэр гонгиноно.

- Зүгээр үү?! – хэмээн Фарамир ой гутам тэр амьтныг нэвт шувт ширтэв. Түүний царайд хилэгнэсэн, өрөвдсөн, гайхсан өчүүхэн ч тэмдэг алга байв.

- Тэгэхээр зүв зүгээр юм биз дээ? Чи хүлүүлэх юм ч хийгээгүй, хагуу шийтгэл ногдуулахаар юм ч хийгээгүй юу? Гэвч аз болоход энэ асуудлыг би шийдэхгүй. Энэ шөнө чи амиараа төлөх хэрэг хийсэн, яагаад гэвэл манай цөөрөмд загас баривал амиараа төлдөг юм.

Хорлум барьж байсан загасаа унагав.

- Бид загас идэхгүй – гэж тэр хэлэхэд:

- Загасанд хамаг хэрэг байгаа юм биш ээ, манай цөөрөм рүү алсаас харсан хэн ч гэсэн үхэх ёстой юм. Фродо гуйсан учраас л би одоохондоо чиний амийг өршөөж байна. Чи Фродод ямар нэг өртэй гэж тэр хэлсэн. Гэвч энд асуудлыг би шийддэг юм. Чи одоо надад хэн гэдэг, хаанаас ирсэн, хаашаа явж байгаа, юу хийдгээ хэлнэ дээ.

- Бид үхсэн, бид байхгүй, биднийг хэн ч гэдэггүй, бид юу ч хийдэггүй, эрррдэнэ байхгүй, юу ч байхгүй. Бүгд хоосон. Ходоод ч хоосон, тийм ээ бид өлсгөлөн. Хоёр муухай ясан загас барьсан, тэгээд л биднийг ална гэж байна. Ямар их цэцэн, ямар их шударга үг вэ!

- Цэцэн нь ч багахан байх аа, гэвч үүнд багахан цэцэн ухаан шаардагдаж байгаа учраас шударгаар шийдье. Энэнийг чөлөөл Фродо – гээд Фарамир бүсэндээ зүүсэн кинжаалаа сугалж Фродод өгөв. Хорлум үхлээ айж, нэгэнтээ чанга орилоод шалан дээр шалхийн унав.

- За, Смеагорл! Чи надад итгэх ёстой. Би чамайг орхихгүй. Чадвал бүх үнэнээ хэл. Муу юм болохгүйг чи үзнэ – гэж Фродо хэлээд Хорлумын хүлээсийг тас огтолж, хөл дээр нь босгов.

- Наашаа ойрт! Миний нүд рүү хар! Чи энэ газрын нэрийг мэдэх үү? Чи урьд нь энд ирж байсан уу?

Хорлум цийлэн бүрэг нүдээ жигтэйхэн дургүй өргөж, Гондорын жанжны тодхон хурц харцтай тулгарав. Хэсэг зуур нам гүм байснаа Хорлум толгойгоо унжуулж, чичрэн дагжсаар өвдгөөрөө ягхийтэл суув:

- Бид энэ газар ямар нэртэйг мэдэхгүй, мэдэхийг ч хүсэхгүй, бид энд хэзээ ч ирж байгаагүй, дахиад хэзээ ч ирэхгүй – гэж тэр гаслан гонгинолоо.

- Чиний зүрх сэтгэлд тас түгжсэн хаалганууд, таг хаасан цонхнууд л байна. Тэнд газар доогуурх шиг тас харанхуй байна. Гэвч одоо үнэн ярьж байгааг чинь би харж байна. Тэгвэл чамд л сайн даа. Чи хэзээ ч дахиад энд ирэхгүй, тандаж мэдсэн замаа үгээр ч, үйлдлээр ч задруулахгүй гэж юугаар андгайлах вэ?

- Юугаар андгайлахыг эзэн мэднэ – гээд Хорлум Фродо руу харснаа:

- Тийм ээ, юугаар гэдгийг эзэн мэднэ. Хэрэв тэр биднийг аврах юм бол эзэндээ тангараглая. Бид түүгээрээ тангараглая – гээд тэр Фродогийн хөл доор өнхөрч:

- Биднийг авраач, сайн эзэн минь! Смеагорл эрдэнээрээ тангарагалж байна, аймшигт тангараг өргөж байна. Тэр энд эргэж ирэхгүй, хэнд ч, юугаар ч задруулахгүй, хэзээ ч үгүй! Үгүй ээ, эрдэнэ минь, хэрхэвч үгүй!

- Чи энэнд итгэж байна уу? – гэж Фарамир асуув.

- Итгэж байна аа, чи ч гэсэн нэг бол итгэх, нэг бол улсынхаа хуулийг биелүүлэх боллоо доо. Өөр зам алга. Хэрэв тэр над дээр ирвэл амьд үлдэнэ гэж би амласан юм, үүнийг хуурч болохгүй.

Фарамир бодолд авган суув.

- За яахав, чиний эзэн Дрогогийн хүү Фродод чамайг хүлээлгэж өгье. Тэр чамайг яахыгаа зарлаг!

- Гэвч эрхэм эзэнтэн та Фродо хэмээгчийн талаар өөрийнхөө шийдвэрийг зарлаагүй байна шүү дээ – хэмэн Фродо мэхийн өгүүлэв: - Тэр шийдвэр гараагүй байхад хоббит би төлөвлөгөө ч зохиож чадахгүй, дагуулуудынхаа хувь заяаг ч шийдэж чадахгүй. Чи шийдвэрээ маргааш болтол хойшлууллаа гэсэн, одоо маргааш болчихоод байна.

– За тэгвэл шийдвэрээ зарлая даа. Ингээд Фродо, надад олгосон эрхийн дагуу би чамайг эртний Гондорын хязгаарт хаа хүссэн газарт чөлөөтэй зорчих эрхтэйг зарлаж байна. Харин энэ газарт дуудаагүй байхад ганцаараа ч, хэнийг ч дагуулж ирэх эрхгүй. Энэхүү шийдвэр энэ мөчөөс эхлэн нэг жил, нэг өдрийн хугацаагаар хүчин төгөлдөр байх бөгөөд дараа нь чи Минас –Тиритэд очиж, эзэн захирагч бөгөөд хотын захирагчийн өмнө зогсоогүй цагт хүчингүй болно. Чамайг тэнд очсон цагт би энэ эрхийг бүх насаар чинь сунгахыг эзэн захирагчаас хүсэх болно. Одоохондоо чиний батлан даасан хэн ч байсан миний хамгаалалтад, Гондорын ивээлд байх болно. Чи энэ шийдвэрт сэтгэл хангалуун байна уу?

Фродо гүнээ мэхийж:

- Би сэтгэл хангалуун байна аа. Хэрэв миний үнэнч зүтгэл өндөр дээд эзний нүдэнд нийцтэй байвал намайг үнэнч зарцаа хэмээн үзэхийг гуйж байна.

- Нийцтэй, бүр багагүй хэрэгтэй. Ингээд чи хариуцагч Смеагорлыг батлан даалтдаа авч байна уу?

- Хариуцагч Смеагорлыг батлан даалтдаа авч байна.

Сэм сүнгэнэтэл санаа алдав. Гэхдээ хэтэрхий албархаг, урт үгэнд дургүйцэж байгаагаа илэрхийлсэнгүй, жинхэнэ хоббитын хувьд энэ үгийг бүрэн дүүрэн дэмжиж байсан боловч манай Хоббитанд бол лав бүтэн сар хэлээд дуусахгүй үг хэлж, бөхөлзөж дуусахгүй их ёслол үйлдэнэ дээ хэмээн харамсч байв.

- Чамд алах ял оноосныг сана, гэвч Фродогийн дэргэд байгаа цагт чамд ямар ч аюул нүүрлэхгүй. Харин Фродогүйгээр харагдах юм бол ямарч Гондор хүн ялын тогтоолыг шууд гүйцэтгэнэ. Хэрэв чи эзнийхээ итгэлийг эвдэх юм бол чамайг хамгийн түргэн бөгөөд аймшигтай үхэл гүйцэх болно. Одоо надад хариу хэл. Та нар хаашаа явж байгаа юм бэ? Фродо чамайг газарчин гэж хэлсэн. Чи эднийг хааш нь дагуулж яваа юм бэ?

Хорлум хариулсангүй.

- Дуугүй өнгөрчихнө гэж байхгүй шүү, хариул, тэгэхгүй бол миний оноох ял хүндэрнэ шүү!

Хорлум хариулсангүй.

- Би түүний өмнөөс хариулья. Тэр миний гуйлтаар биднийг Хар хаалганд хүргэж өгсөн. Гэтэл хаалга хаалттай байсан юм – гэж Фродо хэлэв.

- Энэ оронд нээлттэй хаалга нэг ч байдаггүй юм – гэж Фарамир түсхийтэл хэлэв.

– Тэгээд бид хажуу тийш эргэж, өмнөд замаар явсан, яагаад гэвэл тэнд Минас-Итилд ойролцоо зам байгаа, байхгүй ч гэсэн хайгаад олчихно гэж тэр хэлсэн юм – гэж Фродо яриагаа үргэлжлүүлэхэд:

- Минас-Моргул – гэж Фарамир засав.

- Би яг нарийн ойлгоогүй, гэвч хуучин цайзаас хойт зүг рүү өндөр уул өөд гарсан жим байдаг, тэр жимээр харанхуй ангал руу орно, ангалын нөгөө талаас гарч, доошоо тал руу ордог... гэх мэтчилэн цааш явдаг юм шиг байна лээ.

– Тэр харанхуй ангальг юу гэж нэрлэдгийг мэдэх үү?

- Үгүй. Кирит-Унгол гэдэг юм.

Хорлум хамраараа исгэртэл агаар татаад, амандаа нэг юм бувгнав.

- Тийм үү, үгүй юу? – гэж Фарамир түүнээс асуув.

- Үгүй! – гэж Хорлум сандран хэлснээ гэнэт кинжаалаар хатгасан мэт орилов:

- Тийм тийм, бид энэ нэрийг сонссон, гэвч надад тэрнийг мэдэх шаардлага байхгүй. Эзэн тийшээ явах хэрэгтэй гэсэн, тийшээ нэвтрэх зам байдаг юм бол бид хичээж байна. Өөр хаагуур ч нэвтрэхгүй, байхгүй.

- Өөр хаана ч байхгүй юу? Чи яаж мэдэж байгаа юм бэ? Хар улсын хилийг хэн ч тойрч гарч байгаагүй – гээд Фарамир Хорлум руу удаан, бодлогошронгуй харж байснаа:

- Үүнийг аваад гар, Анборн, Зөөлөн харьцаарай, гэхдээ нүд салгаж болохгүй. Харин чи, Смеагорл, нуур руу шумбах гэж бодсоны хэрэггүй шүү, тэнд маш хурц ирмэгтэй хаднууд бий. Үхэл чамайг цагаас чинь өмнө гүйцнэ. Наад загасаа ав!

Хорлум байдгаараа бөхийж, бараг дөрвөн хөллөн хаалга зүглэхэд Анборн араас нь гарч, Фарамирын дохиогоор хөшиг татав.

- Фродо, миний бодлоор чи ухаангүй юм хийж байна даа, миний бодлоор бол чи энэнтэй хамт явах хэрэггүй. Ялзарсан бузар амьтан байна шүү дээ – гэж Фарамир хэлэв.

- Бүрмөсөн ялзарчихаагүй байх аа.

- Бүрмөсөн ялзарчихаагүй байх, гэвч хорсолдоо нэвт идэгдсэн амьтан байна. Тэр та нарыг сайн юманд хүргэхгүй. Тэрнээс сал, би тэрэнд Гондорын аль хилд хүргэж өгөх хамгаалагч гаргаж өгье.

- Тэр зөвшөөрөхгүй, миний араас аль эртнээс дагаж яваа юм. Тэгээд ч би тэрнийг хамгаалалтдаа авч, тэрний зааж өгсөн замаар явна гэсэн амлалтаа давгчихсан. Итгэлийг эвд гэж чи надад хэлэхгүй биз дээ?

- Үгүй, гэвч миний сэтгэл нэг л зовоод байна. Өөртөө өгсөн амлалтаа зөрчих нэг хэрэг, ёроолгүй ангалын ирмэгээр сохроор бэдэрч яваа хүнд амлалтаа зөрч гэж хэлэх нэг хэрэг. Гэвч нэгэнт л тэр чиний араас салахгүй дагаж яваа бол нүдэндээ ил байлгасан нь дээр биз дээ. Гэхдээ Кирит-Унголоор тэрэнтэй хамт явсны хэрэггүй гэж бодож байна. Тэр Кирит-Унголын талаар мэдэж байгаа юмаа хэлэхгүй байгаа нь даанч илэрхий байна. Кирит-Унголоор бүү яв!

- Тэгээд би хаашаа явах юм бэ? Эргээд Хар хаалган дээр очиж харуулуудад нь баригдах юм уу? Чи тэр гарцыг мэддэг юм уу, яагаад энэ нэрнээс ингэж их айгаад байгаа юм бэ?

- Сайн мэдэх юм байхгүй. Манайхан тэр газарт ойртдоггүй, залуучууд бид Изгарын ууланд ч ойр очиж үзээгүй. Хуучны яриа, эртний домогт л найдахаас өөр юмгүй. Гэвч хүмүүсийн ой тойнд Минас-Моргулаар явах гэдэг нэргүй нэгэн айдас болж шингэсэн. “Кирит-Унгол” гэж хэлэхэд л манай өвгөд болон эртний домог мэддэг хүмүүс царай нь зэвхийгээд дуугүй болчихдог юм. Минас-Моргулын хөндийг бид аль эрт алдсан, хөөгдөж явсан Дайсан эргэж ирээгүй байхад л тэр газар аймшигтай болсон, Итил орны ихэнх нь манай гүрний харьяанд байсан. Нэгэн цагт тэнд манай өнөөгийн нийслэлийн ихрийн өрөөсөн мэт гайхамшигтай гоё, хүчирхэг, бардам Минас-Итил мандаж байсныг чи мэднэ. Гэвч түүнийг Дайсны тоомшгүй олон урьдын гар хөл бологчид - эзэлж авсан юм. Дайсан зугтаж одсоны дараа тэдгээр дээрэмчид тэндхийн хязгааруудад үй олноороо тэнүүчилж байсан юм. Тэдний удирдагчид нь хар шидийн хараалт бөгжнүүдийг эзэмшсэнээс болоод хар эзний боол – амьд сүг, аймшигт хий үзэгдэл болсон нуменорчууд гэж ярьцгаадаг байсан. Тэд Минас-Итилийг орогнох байраа болгож, тэр хотыг ч, ойр хавийн талхөндийг ч хумхийн тоосоор хучсан юм. Цайз эзэнгүй хоосон юм шиг санагддаг байсан. Гэтэл үнэндээ нурсан ханануудыг сүг сүүдрүүд эзэгнэдэг болсон. Дайсны нууцаар бэлтгэсэн Есөн морьтон тэр аймшгийн ханануудын дундаас гарч ирэхэд бид саад хийж чадаагүй юм. Тэдний тэр нүцгэн хад руу битгий ойрт. Чамайг нүд салгахгүй харж байгаад л бариад авна. Үхдлүүд унтдаггүй, тэдний нүдгүй хохимойн хонхрууд унтардаг ч үгүй. Энэ замаар битгий яв!

- Тэгээд ямар замаар яв гэж хэлмээр байна? - гэж Фродо асуугаад:

- Чи өөрөө намайг тэр ууланд хүргээд давуулж өгч чадахгүй гэсэн шүү дээ. Би тэр уулаар давах ёстой, би зөвлөл дээр тийшээ очих зам олно, эсвэл үхнэ гэж ёс төртэй амласан шүү дээ. Хэрэв би аймшигт тавилангаас айж ухарвал хаашаа явах юм бэ? Эльфүүд рүү юу? Хүмүүс рүү юу? Чиний ахыг галзууруулах дөхсөн хар шидийн хараалыг аваад Гондор руу явах уу? Тэгвэл Минас-Тиритийг ямар их гай дайрна гэж бодож байна? Хоёр Минас-Моргул хоёр хохимой яс шиг амьгүй цөлийн хоёр талаас бие бие рүүгээ ярзайж байхын хүсч байна уу?

- Үгүй ээ, би тэгж хүсэхгүй байна

- Тэгвэл надад юу хий гэж хэлэх вэ?

- Мэдэхгүй ээ. Чи нэг бол үхэл рүү, нэг бол тарчилгаа руу явж байна гэж бодохоос надад их зовлонтой байна. Митрандир энэ замыг сонгохгүй л байсан болов уу.

- Гэвч Митрандир байхгүй, тэгэхээр би олдсон замыг өөрөө сонгох ёстой. Эрж хайх цаг алга.

- Буруу шийдвэр, найдваргүй ажил. Гэвч ядаж ганц зөвлөгөөг минь ав. Цаад газарчингаасаа, Смеагорлоос болгоомжлоорой. Тэр нэг биш аллага үйлдсэн. Би алган дээрээ тавьсан юм шиг харж байна – гээд Фарамир санаа алдаж:

- За ингээд бид салъя даа, Дрогогийн хүү Фродо минь. Тайтгаруулах үг чамд хэрэггүй, бид хоёр энэ дэлхий дээр дахиад бараг л уулзахгүй болов уу. Бурхан чамайг болоод чиний ард түмнийг өршөөг. Та нарын замын нөөцийг бэлдэх зуур жаахан амраад ав. Түрүүний ярьсан тэр баталгааг энэ өмхий мөлхөө Смеагорл яаж эзэмшсэн, яаж алдсаныг яривал дуртайяа сонсмоор л байна. Даанч чамд тэрийг ярихтай манатай байна. Хэрэв чи үхлийн хар нүхнээс амьд гараад ирвэл хоёулаа цагаан хэрмийн дэргэд нарны гэрэлд суугаад өнгөрсөн гай зовлонгийн тухай инээмсэглэн хүүрнэлдэх болно, тэр үед энэ тухай ярьж өгөөрэй. Одоо тэр биелшгүй цагийг хүртэл, эсвэл бүхнийг харагч Нуменорын чулуунд ч харагдахгүй огт өөр цаг хүртэл баяртай!

Тэр босч, Фродод гүнээ мэхийн ёслоод хөшгөө яран агуй руу оров.

Бүлэг 17

Замын уулзвар руу

Фродо , Сэм хоёр ор дэвсгэр дээрээ очиж, чимээгүй хэвтэж байх зуур дайчид босч, шинэ өдрийн ажлаа эхэллээ. Удалгүй тэр хоёрт гар нүүрээ угаах ус авчирч, гурван хүнд зориулан зассан ширээнд урив. Фарамир түрүүлээд ирчихсэн сууж байлаа. Тэр бүтэн хоног цурам ч хийгээгүй, тулалдааны дараа ч хэвтэж амраагүй мөртөө өчүүхэн ч ядарсан шинжгүй байв.

Өглөөний хоол идээд шууд босцгоолоо.

- Аян замд өлсөх онцгүй, та хоёрын хүнсний нөөц хомсхон юм байна. Би үүргэвчинд чинь замын хүнс хийлгэсэн. Итил орон усаар баян, гэхдээ Имлад-Моргул, Үхмэл хонхроор урссан ус битгий уугаарай. Миний тагнуулчид, бүр Мораннон руу явсан тагнуулчид хүртэл бүгд эргэж ирсэн. Бүгдээрээ л энэ хязгаар хоосон байна гэж илтгэлээ. Чимээ шуугиан ч үгүй, хөлийн чимээ, бүрээн дуу, нумын хөвчний жингэнээ ч алга гэнэ ээ. Хар орон нам жим байгаа юм байна. Энэ бол тун удахгүй агуу их шуурга болохын дохио гэдэг нь ойлгомжтой. Яарцгааж үз! Та хоёр бэлэн болсон бол явцгаая, одоохон Изгарын уулсын мөнхийн сүүдрийн цаанаас нар мандана – гэж Фарамир яаруулав.

Хоббитуудад түнгийтэл дүүргэсэн үүргэвчүүдийг нь гялалзтал өнгөлж, үзүүрийг нь төмөрлөсөн, сагалдаргатай, сийлбэр бариултай хоёр бөх таяг авчирч өгөв.

- Та хоёрт бэлэглэх юм одоохондоо надад алга, ядаж таяг ав даа. Замгүй газраар ч явна, уул хадаар ч явна. Эред-Нимрайсын уулынхан ийм таягтай явдаг юм, энэ хоёрыг та хоёрын өндөрт тааруулж тайраад шинээр төмөрлөсөн юм. Энэ таягнуудыг гондорын мужаануудын хамгийн дуртай лебетрон модоор хийсэн юм. Энэ мод эрсэн юмаа олоод эргэж ирэхэд тусалдаг ид шидтэй гэдэг юм. Муу муухайн харанхуйд ид шид, гэгээн хүчээ хадгалах болтугай!

Хоббитууд гүнээ мэхийв.

- Гайхамшигт эзэн минь, хагас эльф Элронд биднийг аян замд санаанд ч ороогүй ач тустнууд угтана гэж надад хэлсэн юм. Би үнэхээр ийм сайхан зочилж, ийм их тус хүргэнэ гэж бодоогүй явлаа – гэж Фродо хэлэв.

Хөдлөхөд бэлдэж, Хорлумыг нэг булангаас авав. Тэр дөнгөж саяхных шигээ хачин арчаагүй чигээрээ, Фродод наалдаж, Фарамирын харцнаас гөлөлзөн далдирч байв.

- Газарчны чинь нүдийг бооно, харин чи болон чиний Сэммиумын нүдийг боохгүй.

Нүдний боолт барьсан дайчин Хорлум руу очиход тэр орилон ухасхийж, Фродогоос зуурав. Фродо:

- Бид хоёрын нүдийг ч боочих, эхлээд минийхийг, тэгвэл энэ амьтан өөрийг нь гомдоохыг

хүсээгүй гэж ойлгох байлгүй дээ.

Тэр ёсоор болов. Хеннет-Аннуны агуйгаас урт урт гарц, шатнуудаар явуулсаар өглөөний цэнгэг агаар сэнгэнэтэл үнэртсэн газарт ирлээ. Дахиад жаахан явж, уул руу буугаад боолтыг ав гэж тушаалаа.

Тэдний толгой дээгүүр мөчир ганхаж, навчис шивнэлдэн, хүрхрээний чимээ дуулдахаа болж, тэд голын урд талын уулын бэлд ирсэн байлаа. Баруун талд ертөнцийн хязгаарын ирмэг дээр байгаа юм шиг ой зурайж харагдана.

- Эндээс бид зам сална. Миний үгэнд орж, одоохондоо зүүн зүг рүү битгий эргээрэй. Ой дундуур олон бээр явна. Ойн баруун талаар өргөн хөндий рүү орно. Ойн захыг барьж яваарай. Эхэн үедээ өдөр явахад айлтгүй. Газар дэлхий хуурамч нам гүмд автсан байна. Муу муухай үйлтнүүд нуугдаж байна. Энэ сиймхийг ашигла! – гэж Фарамир хэлээд хоббитуудыг тэвэрч, гондорчуудын салах ёс гүйцэтгэдэг заншлаар мөрөн дээр нь гараа тавиад тонгойн байж духан дээр нь үнсэв.

- Явцгаа даа, сайн үйл та нарын хамгаалагч болтугай! – гэж тэр хэлэв.

Хоббитууд духаа газарт хүртэл мэхийн ёслов. Фарамир зайдуухан хүлээж байгаа дайчид руугаа эргэж харалгүй алхлаа. Нүд цавчих зуурт гурван ногоон хувцаст дайчин огт байгаагүй юм шиг ой руу орж үзэгдэхгүй боллоо.

Фродо нэгэнтээ санаа алдаад өмнө зүг рүү харав. Хорлум юу ч болоогүй юм шиг модны үндэс ухаж байлаа.

- Арай гэж нэг юм тонилов уу? Өөдгүй муу хүний сүгнүүд! Смеагорлын хүзүү өвдсөөр л байна, тийм шшшүү. Хурдан явцгаая!

- Тийм ээ, явчихлаа. Гэхдээ өрөвдөж амийг чинь өршөөсөн хүмүүсийг хараах ямар хэрэг байна, дуугүй байсан чинь дээр шүү! – гэж Фродо зандрав.

- Сайн эзэн минь! Смеагорл хошигнож болохгүй юу? Тэр дандаа бусдыг өршөөдөг. Ийм сайн эзэн, ийм дуулгавартай Смеагорл!

Фродо, Сэм хоёр үүргэвчээ үүрч, таягаа бариад Италийн ойгоор алхлаа.

Энэ өдөр хоёр удаа зогсч, Фарамирын өгсөн замын хүнс болох хатаасан жимс, давсалсан загас идэж, хэсэгхэн амрав. Олон өдөр хүрэлцэхээр хүнстэй болсон бөгөөд талх гэхэд л хатчих вий гэмээр олон байв.

Хорлум хоолноос татгалзлаа.

Нар жаргаж, үл үзэгдэх түүний алтлаг туяа нь тэнгэрийг гийгүүлээд ойн баруун захаар алга болоход тэд сэрүүхэн ногоон бүрэнхий дундуур, дүлий мэт нам гүмд алхсаар байв. Хамаг шувуу нэг бол нисээд явчихсан, нэг бол хэлгүй болсон юм шиг чив чимээгүй. Чимээгүй ойд түргэн харанхуй болж, Хеннет-Аннунаас гарснаас хойш багаар бодоход долоон бээр алхсан

тул ихэд ядарч унтахаар хэвтэв. Фродо хөгшин модны ёроол дахь хөвдөрхөг өвсөн дээр хэвтээд бүхэл шөнийн турш нэг ч сэрэлгүй унтжээ. Сэм түүний хажууд хэвтээд байн байн өндийн харж байсан ч Хорлумын бараа ч алга. Тэр энд ирмэгцээ хаа нэг тийшээ алга болсон бөгөөд ямар нэг нүх рүү шургасан юм уу, эсвэл ямар нэг жижиг амьтан амьдаар нь залгихаар ангуучилж яваа бололтой.

Хорлум өглөөний нарны эхний туяанаар эргэж ирээд, мань хоёрыг сэрээж:

- Босох хэрэгтэй, босох хэрэгтэй! Дахиад хол явна, өмнө зүг рүү, дараа нь зүүн тийш явна. Хоббитууд яарах хэрэгтэй! –хэмээн шавдуулав.

- Өдөр яг л өчигдрийнх шиг өнгөрсөн бөгөөд зөвхөн анир чимээгүй нам гүм улам ихсэв. Агаар хүндэрч, моддын ёроолоор уур савсана. Яг одоохон аянга нижигнэх гэж байгаа юм шиг санагдана. Хорлум зогсч, хамраа сарталзуулан үнэртээд амандаа нэг юм бувтнаж, хоббитуудыг яаруулав.

Гурав дахь өдрийн орой тийшээ ой шингэрч, модод улам томров. Аварга том царснууд мөчрөө ихэмсгээр дэлгэж, тэдгээрийн хоорондуур хөгшин нарснууд сүндэрлэнэ. Ойн чөлөөн дэх ногооны дунд өнгө өнгийн цэцгүүд алаглана. Араатан, шувууд огтхон ч үзэгдэхгүй байсан ч Хорлум ил газраас айж, тэд сүүдрээс сүүдэр рүү дамжиж, бөхийн гүйж байлаа.

Бүрэнхий болоход тэр гурав ойн захад гарч, нуранхай асган дээгүүр үндсээ могой мэт мушгируулсан хөгшин царсны ёроолд суулаа. Тэдний өмнө гүн хөндий сааралтан цэлийж, цаад талд нь хөх саарал ой утаархаг бүрэнхийд өмнө зүг рүү сунаж харагдав. Тэртээ баруун зүгт Цагаан уулын оргилууд жаргах нарны туяанд улайрч харагдана. Зүүн талд тас харанхуй. Мордорын хясаат уулс дөнгөн данган үзэгдэнэ. Их мөрний хөндий тийшээ нарийсан нарийсаар үзэгдэхгүй болжээ. Хөндийгөөр гол урсч, түүний чимээ нам гүмийг эвдэж байв. Голын хажуугаар цайвар тууз мэт зам зурайсаар хар саарал мананд далдарчээ. Андуины эрэг дээр эвдэрсэн өндөр цамхагуудын орой харанхуй мананд хөвж яваа мэт үзэгдэх шиг Фродод санагдав. Тэр Хорлум руу эргэж:

- Бид одоо хаана байгааг чи мэдэж байна уу?

- Тийм ээ эзэн минь, энэ бол маш аюултай газар. Сарны цамхагаас эхэлсэн зам мөрний баруун эрэг дээрх нурсан хотын балгас руу очиж байна. Муухай балгас, тэнд дайсан дүүрэн байгаа. Хүмүүсийн үгэнд орох хэрэггүй байсан юм. Хоббитууд замаас холдсон. Одоо зүүн тийшээ явах хэрэгтэй – гээд тэр харанхуй уулсын зүг шөрмөслөг гараараа дохиод:

- Замаар явж болохгүй, болохгүй, болохгүй! Цамхгаас ирсэн аймшигтай хүмүүс манаж байгаа.

Фродо зам руу харав. Хүн амьтан үл харагдах хоосон зам манан дундуур орхигдсон балгас руу оджээ. Гэвч тэр замаар үнэхээр үл үзэгдэгч амьтад явж байгаа юм шиг зэвүүн мэдрэмж төрж байв. Фродо дахин харанхуй дундах цамхгийн оройнууд руу харахад үхдлүүдийн хонхроос эх авсан хордуулсан Моргулдуин голын ус шуугих дуулав.

- Бид одоо яах вэ? Бид их удаан явсан, их ч хол явсан. Одоо ойгоос гарахаа болиод нэг газар

нуугдаж хонох уу?

- Харанхуйд нуугдаж яах юм бэ? Хоббитууд өдөр л нуугдана биз, тийм ээ өдөр.

- За за, ямар ч байсан амрах хэрэгтэй, ядаж шөнө дунд хүртэл. Дараа нь чи л замаа мэдэж байгаа юм бол харанхуйд бүдчихээс – гэж Сэм хэлэв.

Хорлум дургүйхэн зөвшөөрч, хоббитууд түүний араас зүүн зүг рүү ойн захаар эргэж алхлаа. Тэр аймшигтай замд ийм ойрхон ил газар хонохоос айж байсан учир тэд аварга том царс модны ёроолд, өтгөн мөчрийн доогуур орж, тухтайхан байрлав. Фродо, Сэм хоёр ус балгаж, хатаасан жимстэй талх идэв. Хорлум тэр дороо цагариглан унтаад өгөв. Хоббитууд нүдээ ч аньсангүй.

Хорлум шөнө дундаас хойхно сэрэв. Тэр чагнаж, үнэрлэж эхлэв. Тэр шөнийн цагийг ингэж тодорхойлдгийг хоббитууд аль эрт мэдсэн билээ.

- Бид амарсан уу? Сайхан унтсан уу? Тэгвэл явъя

- Амраа ч үгүй, унтаа ч үгүй. Явах хэрэгтэй бол явахаас даа – гэж Сэм үглэв.

Хорлум модон дээрээс үсрэн буугаад шууд дөрвөн хөллөхөд хоббитууд араас нь удаан буулаа. Хорлум тэр хоёрыг уул өөд өгсүүлэн зүүн зүгийг чиглэв. Тас харанхуй болсон учир тэд мод мөргөх шахаж явлаа. Харанхуйд хонхор хотгор, дов толгод дээгүүр, буган дундуур явах бэрх байсан боловч Хорлум огтхон ч ажирсангүй. Тэр мань хоёр хоббитыг дагуулан урагшилсаар, зүүн талын хадан уулс улам өндөрссөөр байлаа. Эхний даваан дээр гараад эргэж харахад ой тэртээ ард хоцорч, өтгөн харанхуй мэт асар том сүүдэр шиг харагдав. Зүүн талаас харанхуй улам өтгөрч, бүдэгхэн гэрэлтэж байсан одод оргүй алга болов. Дараа нь жаргаж байгаа сар үүлсийн цаанаас дөнгөж цухуйлаа.

Эцэст нь Хорлум хоббитууд руу эргэж хараад:

- Удахгүй өдөр болно, хоббитууд яарах хэрэгтэй. Энд өдрийн цагаар ил газар байж болохгүй, яасан ч болохгүй. Хурдлаарай! – гэлээ.

Тэр урьдынхаасаа хамаагүй хурдан явахад хоббитууд арай ядан гүйцэж байв. Харгана, шаваг, намхан буттай өндөр хадан хясаа тулж, саяхан түймэр болсны гэрч хуйхлагдсан төгөл байн байн тааралдаж байв. Хоббитууд өргөст буган дундуур бараг бөхийлгүй явж байлаа.

Ээлжит нэг уулыг даваад буган дунд амрахаар суув. Ихэд ядарсан тул юм идэх дур ч байсангүй, буган дотроос цухуйн ийш тийш харж, өдөр болохыг хүлээлээ.

Гэвч өдөр шиг өдөр болсонгүй, зүгээр л саарал бүрэнхий нөмрөв.

- Одоо бид хаашаа явах вэ? Энэ гүвээний цаана Моргулын хонхор байгаа юу? – гэж Фродо асуув.

- Асуугаад байх юу байна? Одоохондоо бид цаашаа явахгүй, ямар ч гэсэн өдөр шүү дээ – гэж

Сэм хэлэв.

- Одоохондоо цаашаа явсан ч болно, явахгүй байсан ч болно. Гэвч хурдхан явах хэрэгтэй байна. Замын уулзварт л хурдан хүрэх хэрэгтэй байна. Эзэн зөв бодсон байна, бид тийшээ явна – гэж Хорлум яарууллаа.

Мордорын дээгүүрх хүрэн улаан туяа унтарч, бүрэг харанхуй өтгөрөн, зүүн зүгээс хөөрсөн утаан үүл тэдний дээгүүр мөлхөв. Фродо, Сэм идэж ууж аваад унтахаар хэвтсэн ч Хорлум хоол идсэнгүй, жаахан ус уугаад хонхроос мөлхөн гарснаа сураггүй болов.

- Хулгана мулгана ангуучилж яваа биз – гэж Сэм хэлээд эвшээв. Түүний унтах ээлж болсон тул тэр дороо нам унтлаа. Тэрбээр Ууган хясаан дээрх ногооны талбайд нэг юм хайгаад байна гэж зүүдэлжээ. Тэр хүнд ачаа үүрсэн, хамраараа газар хатгах шахан зүтгэж байна. Ногооны талбай манжингаар хөл гишгэх газаргүй дүүрчээ. “Мөн ч их ажил байна даа, гэтэл би үхлээ ядарсан байдаг” гэж тэр өөртөө хэлснээ гэнэт юу хэрэгтэй байгааг санахад. Гаанс минь хаа байна!” – гэж хэлээд тэр сэрлээ.

- Мангуу толгой! – хэмээн өөрийгөө хараагаад “Би яахаараа ногооны талбайн хашааны ёроолд хэвтэж байдаг билээ” гэж бодов. Тэгснээ гаансаа хайх хэрэггүй, тэр үүргэвчинд байгаа, тамхи байхгүй, мөн Ууган хясаанаас олон зуун бээр хол байгаагаа мэдэв. Босч суулаа. Тас харанхуй.

- Та бүрмөсөн унтчихаагүй биз, эзэн минь? Хэдэн цаг болж байна? Орой болсон юм шиг байна.

- Орой болоогүй ээ, зүгээр л өдөр улам харанхуйлж байна. Үд дунд л болж байгаа байх, чи гурван цаг л унтсан.

- Сонин л юм болж байна даа. Шуурга эхлэх гэж байгаа юм болов уу? Ийм шуурга ертөнц дээр болж байгаагүй байх аа. Сайн нуугдсан нь дээр байх, гэтэл бид хоёр мөчрөөр халхавчлаад сууж байдаг – гээд тэр чагнаснаа:

- Энэ юу вэ? Аянга уу, бөмбөр үү?

- Мэдэхгүй ээ, аль түүрүүнээс хойш л нижигнээд байгаа юм. Газар чичрээд байгаа юм уу, чих шуугиад байгаа юм уу бүү мэд.

Сэм эргэн тойрноо харав.

- Хорлум хаачив аа? Эргэж ирээгүй юм уу?

- Алга л байна, чимээ ч байдаггүй, бараа ч байдаггүй.

- Ямар гарзтай юм биш, би урьд нь хэзээ ч ийм хог новш замд авч гарч байгаагүй. Зуун бээр газар хүзүүнээс зүүгдчихээд яг хэрэг болохоороо алга болно гэж юу гэсэн үг вэ? Гэхдээ тэрний хэрэг ч гэж юу байхав дээ.

- Чи намагт яаснаа юу ч гэсэн битгий март. Тэрэнд юу ч тохиолдиогүй байх гэж найдаж

байна.

- Харин би тэрнийг муу үйл сэдээгүй байгаасай, ядаж дайсны гарт ороогүй байгаасай гэж залбирч байна. Тэгвэл ч бид хоёр хэцүүднэ шүү.

Дахиад л бүр ойрхон нижигнэх сонсогдов. Хөл доорх газар чичирч байлаа.

- Юуны чинь хэцүүдэх. Бид хоёрын аялал дуусч байх шиг байна даа.

- Тийм ч байж магадгүй. Миний Жихарь: “Амьсгалж байгаа цагт амьд байна. Амьд байгаа бол идэх хэрэгтэй” гэдэгсэн. Та жаахан юм ид эзэн минь, тэгээд унт.

“Өдөр бол өдөр л биз, биш бол тэр л биз” - гэж Сэм бутан нуувчнаасаа цухуйж, ийш тийш хараачлангаа бувгнав. Хар хүрэн харанхуй хараа үл нэвглэх манан болж хувирчээ. Хүйтэн мөртөө амьсгал давчдам бөгчим байв. Фродо тайван унтаж чадахгүй эргэж хөрвөөн, нойрон дундаа үглэж байлаа. Гэндальфын нэрийг хоёр ч удаа хэлэв. Цаг хугацаа нэг л зэвүүн аймшигтай өнгөрч байв. Эцэст нь хэн нэгэн ард нь шуухитнахыг сонсоод Сэм эргэж хартал Хорлум дөрвөн хөллөн зогсч, нүд нь цийлэгнэн гялалзаж байв.

- Босоорой, босоорой! Босоорой унтаахайнууд аа! Түргэн босоорой! Сатаарч болохгүй, яасан ч болохгүй. Явах хэрэгтэй байна, яг одоо явах хэрэгтэй байна. Яасан ч саатаж болохгүй! – гэж тэр сандчив.

Сэм түүн рүү гайхан харлаа. Үхглээ айсан юм болов уу, эсвэл зүгээр л шогтож байгаа юм болов уу?

- Яг одоо юу? Чи юу болчихоо вэ? Болоогүй байна. Үдийн хоолны цаг ч болоогүй байна. Аятайхан айл хоолны ширээгээ ч засах болоогүй байна шүү дээ.

- Шшшал тэнэг! – хэмээн Хорлум исгэрч:

- Бид чиний тэр аятайхан айлд чинь байгаа биш. Цаг урсч байна, цаг хурдалж байна, дараа нь хожимдсон байна шүү. Сатаарч огт болохгүй! Явах хэрэгтэй! Босоорой эзэнтэн минь, босооч!

Тэр Фродогийн мөрнөөс базан сэгсрэхэд Фродо гэнэт сэрж, өндийн суугаад түүний гарыг шүүрч авлаа. Хорлум түүний гараас мултарч хойшоо ухрав:

- Тэнэглэх хэрэггүй, явах хэрэгтэй. Сатаарч болохгүй!

Яагаад яарах хэрэгтэй болсныг тэр асуугаад ч хэлсэнгүй, хаашаа алга болоод ирсэн, яагаад ингэж яарч байгаагаа хэлсэн ч үгүй. Энэ нь Сэмд даанч сэжигтэй санагдсан ч Фродо энэ талаар бодсон шинж алга. Тэр нэгэнтээ санаа алдаад, үүргэвчээ үүрэв. Хаашаа ч байсан хамаагүй харанхуй дундуур алхахад бэлэн байгаа харагдана. Хорлум тэр хоёрыг уул өөд туйлын болгоомжтой дагуулан өгсөв. Боломжтой газар болгонд нуугдаж, ил газар хар хурдаараа гүйж байсан учир хамгийн соргог араатан ч эльф цув юүдэнтэй хоббитуудыг олж харах аргагүй байсан бөгөөд тэр хоёр жинхэнэ эльф шиг чив чимээгүй явж, нэг ширхэг өвс ч шархийсэнгүй.

Тэд цаг гаруй өтгөн харанхуй дундуур чимээгүй цувран явж байхад ууланд байн байн аянга юм уу, бөмбөр ч юм уу бүү мэд нижигнэн хүржигнэсээр байлаа. Тэд улам баруун тийш даялан өргөст бутан дундуур доош уруудсаар байлаа. Тэгсээр ойрхон газарт хэсэгхэн ой харагдлаа. Ойртож очиход ой харанхуй хана болон ханарч тослоо. Модод машинд хөгшин, аварга том бөгөөд аянганд цохиулсан мэт түлэгдэн харлаж, орой нь хугарсан боловч ихэмсэг сүрлэг хэвээрээ, ямар ч ширүүн шуурга тэднийг унагаж чадахааргүй, эсвэл олон зууны настай үндсийг нь эх газраас сугалж чадахааргүй дэндүү бат бөх үзэгдэв.

- Замын уулзвар байна, бид үүнийг тойрох аргагүй – гэж хонхроос гарснаас хойш нэг ч дуугараагүй Хорлум хэлэв.

Тэр зүүн зүг эргэж, уул өөд өгстөл тэдний нүдний өмнө гэнэт өмнөд зам мэлтэсхийтэл гараад ирэв. Зам уулын бэлээр мушгиран моддын дундуур үзэгдэхгүй болжээ.

- Өөр явах газар байхгүй, энэ замаас цааш жим ч байхгүй, зөрөг ч байхгүй. Уулзвар хүрэхээс өөр аргагүй, түргэлэх хэрэгтэй! Нэг ч үг дуугарч болохгүй! – гэж тэр шивнэв.

Тэд дайсны үүрэнд орсон тагнуулчид шиг зам руу мөлхөж, замын баруун далан руу муур мэт хэдхэн харайж хүрэв. Тэгээд нурсан ордны багана мэт эгнэсэн модод дунд орлоо. Моддын дунд дөрвөн замын уулзвар байна. Нэг зам нь хойшоо, Мораннон руу, нөгөө нь өмнө зүг рүү, баруун тийшээ эртний Осгилиат хүрэх зам байх бөгөөд тэр зам их замыг хөндлөн огтлоод зүүн зүг рүү оджээ. Тэдний зам тийшээ байлаа..

Фродо айсандаа хоромхон зуурт нам зогсоод, эргэн тойронд гэгээтэй болж, алсын гэрлийн гялбаанд Сэмийн царай гэрэлтэхийг харав. Тэрбээр чангалж татсан тууз шиг Осгилиат руу одсон зам руу харлаа. Хар сүүдэрт хучигдсан Гондорын дээгүүр, удаанаар мөлхөж буй тугалган үүлсийн хормой дороос нар цухуйж, түүний жаргаж буй туяа хараахан бузарлагдаагүй байгаа Тэнгис рүү тусч байв. Тэгтэл Андуины аварга чулуун хөшөөнүүдээс багагүй, нүсэр том суугаа хөшөө үзэгдэв. Мянга мянган жилийн салхинд элэгдсэн тэр хөшөөг саяхан эвдэлж нураасан нь илт. Толгойг нь авч хаяад оронд нь том бөөрөнхий чулуу тавьсан байх бөгөөд ямар ч ургүй будаг нялсан, духан дээрээ ганц улаан нүдтэй нүүр нь дарвайтал инээжээ. Өвдөг, өндөр суудал болон суурин дээр хараал зүхлийн бүдүүлэг үгс сараачиж, мордорын заваан дүрс үсгүүдийг эрээчсэн байв.

Фродо жаргах нарны сүүлчийн туяанд замын хажууд хаягдсан эртний хааны толгойг гэнэт олж харав.

- Хараач, Сэм! Титэмтэй юм байна – хэмээн гайхсандаа ээрэн байж хэлэв.

Хөшөөний нүдийг ухаж, сахлыг нь тайрч хаясан боловч алт-мөнгөн титэм нь хэвээрээ байлаа. Хааны толгойг өнгө өнгийн цэцэгс нандигнан хадгалах мэт бүрхжээ.

- Тэр мөнхөд ялагдчихаагүй! - гэж Фродо хэлэв.

Нар хагарсан дэнлүү мэт унтарч, харанхуй улам өтгөрөв.

Бүлэг 18

Крит - Унголын ойролцоо

Хорлум Фродогийн цувнаас угзарч, айж, тэсч ядсандаа дагжин чичрэв.

- Явах хэрэгтэй. Энд зогсч болохгүй. Огт саатаж болохгүй!

Фродо дуртай дургүй зүүн тийш эргэж, газарчийнхаа араас модон дотроос гараад, уул өөд гарсан замаар алхлаа. Зам эхлээд шулуухан явж байснаа удалгүй өмнө зүг рүү эргэж, толгод дээрээс харагдаж байсан аварга том цохио руу дөхөв. Цохионы сүүдэр замыг хааж, зам сүүдрийн цаад талаас уул өөд эгц өгсчээ.

Фродо, Сэм хоёрын зүрх шимшрэх шиг болж, айхаа ч больжээ. Фродо толгой гудайн хөлөө зөөж тавина. Хүзүүн дэх ачаа нь дахиад л хүндэрч байлаа. Итилид ирээд бараг мартагдсан ачааны дарамт Уулзвараас хөдлөнгүүд дахин мөч өнгөрөх тусам хүндэрсээр байв. Хөл дорх зам улам л өгсүүр болж, тэр нүдээ ядрангүй өргөн харвал яг л Хорлумын хэлсэнчлэн бөгж эзэмшигчдийн цайз чанх толгой дээр нь харагдав. Түүнийг цайзын хэрмийн шагайвчууд өөрийн эрхгүй соронздон татаж байлаа.

Урт хөндий улам нарийссаар уул руу жадны үзүүр мэт орж, цаад талд нь, Эфель-Дуатын өвдөг мэт өндөр дэвсэг дээр Минас-Моргулын цамхаг, хэрэм сүндэрлэж үзэгдэнэ. Хар газрыг хар тэнгэр хучиж, цайз илжирсэн хүүр мэт юуг ч үл гэрэлтүүлэх үхмэл өнгөөр цайран харагдана. Нэгэн цагт энэ цайз эргэн тойрны уулсыг гялбуулан гэрэлтүүлж агсан билээ. Цамхгийн цонхнууд хохимойн ухархай мэт онгойн харлаж байлаа. Аянчид тийш харж, илбэдүүлсэн мэт нам зогсон, бие нь агзасхийв. Хорлум түрүүлж сэхээ ороод, тэр хоёрын цувнаас чангаан чирэх шахам урагшлав. Алхам бүхэн тамлагаа мэт санагдаж, цаг хугацаа зогссон юм шиг, тэд хөлөө арайхийн зөөж байв.

Ингэж явсаар Цагаан гүүр хүрлээ. Зам хөндийн дундуур урссан голыг гатлаад хэрмийн хойт ханан дахь онгорхой хар ам мэт хаалга руу муруйж тахирлан хүрчээ. Голын хоёр эрэг нь намхан налуу, түүнээс цааш манант нуга залгажээ. Нуга нь нэг л сонин, аймшигт зүүдэнд үзэгдэж байгаа юм шиг гоё мөртөө айдас хүрэм, булшны илжэрхий үнэртэй ажээ. Гүүр нэг нугаас нөгөө нуга руу хөтөлсөн байх ба наад захад нь очиход хүн, амьтны дүрсийг ер бусаар гажуудуулан уран нь аргагүй дүрсэлсэн баримлууд байна. Голын ус чимээгүй урсан, гүүрийн тулгууруудыг үхмэл хүйтэн, хортой уураараа хүрээлжээ. Фродогийн толгой эргэж, нүд нь харанхуйлж байснаа гэнэт ямар нэг үл үзэгдэгч хүч түүний хүсэл зоригийг дийлсэн мэт агдан яарч, гараа ургаш сунгаад, толгойгоо салгануулан гүйх аядав. Сэм, Хорлум хоёр араас нь ухасхийлээ. Сэм эзнээ барьж авахад цаадах нь бүдэрч, гол руу уначих дөхөв.

- Ийшээ биш! Ийшээ л биш шүү! – хэмээн Хорлум шивнэхэд түүний шүдний завсраар гаргасан исгэрээн нам гүмийг эвдсэн тул тэр айсандаа газарт нам унав.

- Зогсоорой, эзэн минь! Арагшаа, буцаад! Бид ийшээ явахгүй, энэ удаад би Хорлумтай санал нэг байна – гэж түүний чихэнд шивнэв. Фродо алгаараа духаа нэг илээд өндөр дээрх цайзаас

нүдээ салгалаа. Гэрэлтэн буй цамхаг түүнийг соронздон татаж, тэр цайран харагдаж байгаа замаар орон хаалга руу хар хурдаараа гүйх шаналгаат хүсэлтэйгээ хамаг тэвчээрээ шавхан тэмцэлдэж байв. Эцэст нь тэр хүслийг арайхийн дийлсэн боловч бөгж түүнийг дахиад л гүүр рүү чангааж, эргэж харахад нүд нь гэнэт юу ч харахаа болилоо.

Хорлум үхтлээ айсан нохой мэт мөлхөн холдож, харанхуйд бараг үзэгдэхээ болив. Сэм бүдрэн чаргууцалдах эзнээ сугадан түүний араас яарав. Голын эргээс холгүй, замын хажуугийн хананд том нүх гарсан, түүний цаана бас л бүдэгхэн цайвартсан жим харагдах бөгөөд булшны цэцгүүд бүхий нугыг өнгөрөөд уул өөд тахирлан өгсөхдөө бүдэгрэн харлажээ. Хоббитууд тэр жимээр зэрэгцэн алхахад Хорлум түрүүлэн алга болсноо эргэж, тэр хоёрыг дохио зангаагаар дуудаж байв. Түүний нүд цийлгэр ногооноор гэрэлтэж харагдах бөгөөд нэг бол үхмэл гэрэл туссан, эсвэл нүд нь өөрөө гэрэлтэж байгаа бололтой. Үхмэл гэрэл, цамхгийн харанхуй ухархайг Фродо, Сэм хоёр нуруугаараа үргэлж мэдэрч, эргэн тойрноо айсан нүдээр харж, харцаа үл үзэгдэх жим рүү хүчээр эргүүлж явлаа. Тэр хоёр хөлөө арайхийн зөөж, хордуулсан голын ууршилтаас дээш гарч ирсэн хойно л амьсгалахад хөнгөн болсон ч хөл, гар нь тугалга цуггасан мэт болж, бүхэл шөнөжин чулуу зөөсөн юм уу, голын урсгал сөрж сэлсэн юм шиг ядарсан байв. Эцэст нь цааш явах тэнхэлгүй боллоо.

Фродо зогсч, чулуун дээр суув. Тэд нүцгэн хясааны орой дээр гарч ирсэн байх бөгөөд жим нь цаашаа хясааны ирмэгээр эргээд харанхуйд үзэгдэхгүй болжээ.

- Би жаахан амармаар байна, Сэм, бөгж хүзүүнээс ямар их хүндээр чангааж байна гээч, найз минь, ёстой хүнд байна! Би үүнийг хол тээж чадахгүй нь. Ямар ч гэсэн эхлээд амрах хэрэгтэй, тэгэхгүй бол...- гээд тэр харанхуй ангал руу заав.

- Шшшш! Шшш! - хэмээн Хорлум түргэн эргэж ирээд шивнэж: - Шшш! – гээд хуруугаа амандаа нааж, Фродогийн гараас татан жим рүү заав. Фродо хөдөлж ч чадахгүй байлаа.

- Хүлээ, хүлээж бай – гэж тэр үглэх ба ер бусын их ядаргаа түүнийг илбэдсэн мэт хүлж байв.

- Үгүй ээ, амрах хэрэгтэй – гэж тэр давтан үглэнэ.

Айсандаа Хорлум дахин ярьж эхлэв. Тэр үл үзэгдэх чихнүүдээс үгээ нууж байгаа мэт гараараа амаа халхавчлаад:

- Энд л биш, энд амарч болохгүй. Тэнэгүүд! Биднийг нүднүүд харж байна. Гүүрэн дээрээс харж байна. Хурдан явцгаая. Дээшээ, дээшээ! хурдал!

- Явцгаая эзэн минь, тэрний зөв. Энэ бол амрах газар огт биш – гэж Сэм хэлэв.

- За за - гэж Фродо нойрон дундаа ярьж байгаа юм шиг бүдэгхэн хэлээд: - оролдоод үзье – гэлээ.

Тэгээд хөл дээрээ арайхийн босов.

Гэвч оройтжээ. Тэдний хөл доорх хаясаа доргин чичирхийлэв. Өмнөхөөс хамаагүй чанга

нижигнээн хөндийгөөр дамжин ууланд цууриалав. Тэнгэрийн зүүн хойт хэсэгт асар том гал манасхийж, намхан үүлс хүрэн улаанаар туяарав. Тэгээд аянга нижигнэлээ.

Минас-Моргул хариу өгч, тэнгэрт гал цахилгаан маналзан, үүлсийг хөхөвтөр дөлөөр зүслээ. Газар дэлхий ёолон, цамхгаас зэрлэг орилолдоон чих дөжрүүлэв. Тэр орилоонд махчин шувуудынх шиг сөөнгө хашгираан, айсандаа галзуурах шахсан адууны янцгаалт сонсогдох шиг болсон ч дараа нь зүрх зүсэм аймшигт хашгираан агаарыг буцалгах мэт болов. Хоббитуудыг дээш хөөргөснөө газарт шидэхэд тэд гараараа чихээ дарлаа.

Чимээ намжихад Фродо толгойгоо аажуухан өргөв. Нарийхан хөндийн нөгөө талд үхэл тээгч цайзын хана сүглийж, хаалганууд нь араа шүдтэй ам мэт ангайжээ. Тэндээс цэргүүд гарч ирж харагдав. Тэд цөм шөнө шиг хар хувцастай ажээ. Гэрэлтүүлсэн чулуун хавтан замаар хар цэргүүд эгнээ эгнээгээрээ, хурдан бөгөөд чимээгүй, эцэс төгсгөлгүй цувсаар байв. Морьт цэргийн эгнээнүүд түрүүлж, тэргүүнд нь бусдаасаа том морьтой, бусдаасаа өндөр, хар цув, хар хуягтай морьтон явах бөгөөд нүүр рүүгээ буулгасан юүдэнгийнх нь дээр дуулга ч юм уу, титэм ч юм уу нэг юм үхэнгэ өнгөөр гялалзана. Тэр гүүрэнд дөхөж ирэхэд Фродо бүлтийсэн нүдээ түүнээс салгаж ч чадахгүй, цавчилж ч чадахгүй байв. Есөн бөгжтөний тэргүүн тоолшгүй олон цэрэг дагуулаад газар дээр ирсэн гэж үү? Тэр үнэхээр мөн байлаа. Фродог үхлийн хорт илдээр шархдуулсан мөсөн гарт, хамгийн ясархаг үхдэл хаан өөрийн биеэр явж байлаа. Фродогийн хуучин шарх аймшигтайяа янгинан, зүрх нь хүйт даав.

Айсан, гайхсандаа Фродо газарт шигдэн хөдөлж чадахгүй байтал хар морьтон гүүрийн дэргэд ирмэгц гэнэт зогсоход бүх цэрэг нь зогслоо. Нам гүм амьсгал давчдуулна. Сүг сүүдрүүдийн жанжин бөгжний дуудлагыг сонссон бололтой, тэр өөрийнхөө хөндийд өөр хүч байгааг мэдрээд сандарч байх шиг. Үхлийн титэмт хар толгой ийш тийш эргэлдүүлэн, үл үзэгдэх нүдээрээ харанхуйг тэмтрэн байв. Фродо мөлхөн ойртож байгаа могой үзсэн дэгдээхий мэт хөшиж, бөгжийг хуруундаа угла гэсэн тушаал урьд өмнөхөөс зуу дахин хүчтэй байгааг мэдэрч байлаа. Гэвч одоо тэр тушаалд захирагдахыг өчүүхэн ч хүссэнгүй. Бөгж намайг барьж өгнө, би Моргулийн эзэнтэй тулалдаж хүч хүрэхгүй гэдгээ тэр сайн мэдэж байв. Үхлийн айдаст хүлэгдсэн тэрбээр гадны ятгалгыг мэдэрч байсан ч хариу өгсөнгүй. Хар морьтны гар хөдөллөө. Фродо аймшгийн зохиол уншиж байгаа юм шиг түүнийг ширтэж байснаа хуруу нь хүзүүн дэх гинж рүүгээ дөхөв. Гэвч Фродогийн ухаан сэргэж, гараа зүрхэн тушаагаа нуусан Галадриэлийн аяганд хүргэв. Тэр аягыг энэ хором хүртэл таг мартсан байлаа.

Яг тэр хоромд хар морьтон морио давирч, гүүрэн дээр гарахад хар цэргүүд нь түүний хойноос төгсгөлгүй цуваагаар хөдөллөө. Магадгүй, түүний үл үзэгдэгч хурц нүдийг эльфийн цув хуурсан ч байх, ухаан, зоригоо хөвчилсөн жижигхэн дайсан түүнд харагдалгүй өнгөрөв. Тэгээд ч тэр их яарч явлаа. Эзнийхээ тушаалаар тэр баруун газрыг дайлаар мордож байгаа нь энэ билээ.

Тэрбээр муруй тахир замаар аймшигт сүүдэр болон довтлоход цэрэг нь гүүрээр эцэс төгсгөлгүй цуварсаар л байв. Исилдурын үеэс хойш Минас-Итилийн хөндийгөөр ийм их цэрэг цувж байсан нь үгүй, Андуины гармаар ийм хүчирхэг их цэрэг гаталж байсангүй. Гэхдээ энэ бол Мордороос гаргасан цэргийн зөвхөн нэг л анги байв.

Фродо Фарамирын тухай бодлоо. “Шуурга ч эхэллээ дээ. Осгилиат руу төмөр үүл нүүж

байна. Фарамир мөрнийг гаталж амжаа болов уу? Тэр ийм юм болно гэж мэдэж байсан ч гэсэн гэнэдэхгүй байгаа? Гондорчууд гармыг хамгаалж хүч хүрэхгүй. Есөн бөгжтөний тэргүүн бөгжтөний өмнө хэн тэсэх билээ. Тэрний араас дахиад үй олон цэрэг хүч нэмнэ. Би хожимджээ. Бүх юм өнгөрлөө. Би замдаа их саатжээ. Бүх юм өнгөрлөө. Би даалгаврыг биелүүллээ ч гэсэн хэн ч, хэзээ ч тэр тухай мэдэхгүй. Амьд үлдсэн нэг нь хэндээ ярих юм бэ?”. Тэрбээр гутарсандаа асгартал уйлж байхад Моргулийн цэрэг гүүрээр цувсаар л байв.

Дараа нь, Хоббитанид өглөөн нарны анхны туяатай уралдан айлуудын хаалга нээгдэж байх үес “Сэрээрэй, босоорой” хэмээн дуудаж байгаа юм шиг Сэмийн дуу холоос дуулав: “Сэрээрэй, эзэн минь! Сэрээрэй”. Хэрэв “Өглөөний хоол ширээн дээр бэлэн” - гэж хэлсэн бол Фродо гайхахгүй байх байлаа.

- Сэрээрэй эзэн минь, тэд явчихлаа!

Минас-Моргулын хаалганууд чихран хаагдав. Цэргийн сүүлчийн эгнээ манан дунд үзэгдэхгүй болов. Цамхаг хар сүүдэрт хучигдаж, урьдын адил нам гүм болсон ч харанхуй хар цонхнуудаас нь үл цавчигч нүднүүд ширтсээр байлаа.

- Сэрээрэй эзэн минь! Тэд явчихлаа, бид ч гэсэн даруйхан хөдлөх хэрэгтэй байна! Тун ч соргог нүд энд харуулдаж байна. Биднийг харах л юм бол тэр дор нь эд бад хийчихнэ. Энд саатаж огт болохгүй. Нүд ирмэх зуурт л дараад авна. Явцгаая эзэн минь!

Фродо толгойгоо өргөж, хөл дээрээ босов. Гутрал цөхрөл арилаагүй боловч хүч тэнхээ нь сэргэжээ. Тэрбээр муухан мушилзан инээвхийлэв. Сүүлчийн хүчээ шавхан байж үүргээ биелүүлэх ёстой, тэр тухай Фарамир, Арагорн, Элронд, Галадриэль, Гэндалф нар мэднэ үү, байна уу – гучин гуравдугаар асуудал гэдэг нь түүнд тов тодорхой боллоо. Тэр нэг гартаа таягаа барьж, нөгөө гартаа галадриэлийн аягыг барьж байв. Хуруунуудынх нь завсраар хурц гэрэл гарч байгааг хараад тэр аягаа өвөртөлж, зүрхэндээ наалаа. Тэгээд Моргулийн цайзаас хараагаа салгаж, замаа хөөв.

Хорлум Минас-Моргулийн хаалга нээгдмэгц хоббитуудыг орхиж, дээшээ харанхуй руу мөлхөн ороод цэргүүд явж дуусангуут эргэж ирэв. Шүд нь тачигнаж, урт хуруунууд нь чичирнэ.

- Усан тэнэгүүд! Хар малууд! Саатаж болохгүй! Аюул өнгөрлөө гэж битгий бодоорой, үгүй шүү. Саатаж болохгүй!

Тэр хоёр хариу хэлэлгүй араас нь дагаж, ангалын ирмэгээр алхлаа. Хичнээн олон аймшигийг давж ирсэн боловч ёроолгүй ангалын ирмэгээр явах аймшигтай байв. Удалгүй жим хясааны ирмэгээс холдож, нарийхан хонгил руу орсон нь Хорлумын хэлсэн эхний шат бололтой. Тэнд өөрийнхөө гарыг ч харахааргүй харанхуй, зөвхөн дээрээс хоёр цийлэн ногоон гэрэл харагдсан нь Хорлум эргэж харсан ажээ.

- Болгоомжжжтой! Энд гишнүүрнүүд, олон олон гишгүүр байгаа. Машшш болгоомжжтой явах хэрэгтэй!

Тэр үнэхээр худлаа хэлсэнгүй. Фродо, Сэм хоёрт арай хөнгөн болсон ч хоёр талаас хана

шахаж, шат нь бараг эгц босоо байсан бөгөөд дээшээ авирах тусам доороос харанхуй нүх улам хүчтэй татаад байлаа. Шатны гишгүүрүүд нь нарийхан, жигд биш, халтирамхай, өмхөрч муудсан, зарим нь хөл хүрэнгүүт бутарч байв. Хоёр хоббит мэдээ алдаж дуулгаваргүй болсон хуруунуудаараа дээд талын гишгүүрүүдээс барьж, янгинан өвдөж байгаа өвдгөө яаж ийгээд нугалан өгссөөр байлаа.

Эцэст нь гар хөл хоёр ямар ч мэдээгүй болоход дахиад дээрээс Хорлумын хоёр нүд харагдав.

- Гараад ирлээ. Эхний шат дууссан. Ухаантай хоббитууд их өндөрт гарч ирлээ. Маш их өндөрт. Одоо хэдхэн гишгүүр өгсөөд дуусна.

Сэм найган уухилсаар сүүлчийн гишгүүр дээр гарахад араас нь Фродо гарч ирээд өвдөг, тавхайгаа үрж гарлаа. Одоо тийм ч эгц босоо биш, шатгүй гарц үлджээ. Хорлум тэр хоёрыг амраасангүй:

- Цаана нь өөр шат байгаа, ихээ урт. Түүгээр гарсны дараа амраарай. Энд амарч болохгүй.

Сэм ёолов:

- Их урт гэнэ ээ?

- Тийм ээ, их урт. Гэхдээ хөнгөн. Хоббитууд шулуун шатаар өгссөн. Одоо тойрдог шат эхэлнэ.

- Тэнд юу байгаа вэ? - гэж Сэм асуув.

- Тэнд очиж байж л үзье. Тийм ээ, тэнд очиж байж үзнэ! – гэж Хорлум аяархан хэлэв.

- Тэнд гарц байгаа гэж чи хэлсэн шүү дээ. Харанхуй гарц байдаг гэсэн байх аа?

- Тийм ээ, хясаан доогуур урт хонгил байгаа. Гэхдээ хоббитууд эхлээд амарна. Одоо шатаар дээшээ гарчихвал бүх юм сайхан болно. Энэ хамгийн дээд тал нь. Хоббитууд дээшээ гарчихвал орой дээр нь гарлаа гэсэн үг. Тийм шшшүү.

Фродо авирч байхдаа их хөлөрч, чичрүүдэс хүрэн, хувцас биенд нь наалдаж байлаа. Хонгилын дээрээс салхи нэвт үлээж байв. Тэр босч шилгээгээд:

- Явья даа, энд суух арга алга, нэвт салхилж байна - гэв.

Тэд нэлээд удаан явж, хүйтэн салхи үлээж байснаа шуурга исгэрэв. Уулын уур хүрч, харийн аянчдыг нуруун дээрээсээ сэгерэн харанхуй ангалд хийх гэж байх шиг. Эцэст нь баруун талын ханан хад алга болсон нь ил гарсны шинж бололтой. Гэвч бараг гэрэлтэй болсонгүй. Дүнсгэр хадан цохионууд өтгөн саарал сүүдэр унагаж, намхан үүлэн доогуур улаавтар гэрэл байн байн улалзаж, урд талд нь өндөр хадан оргилууд үзэгдэв. Тэд олон зуун фут өндөрт өргөн дэвсэг дээр гарч ирэхэд зүүн талд хясаа, баруун талд ёроолгүй харанхуй байлаа.

Газарчин Хорлум хясаанд наалдаж, харанхуйд нуранги асган дээгүүр таамгаар урагшилж байв. Тэд Моргулийн хөндийд орж ирснээс хойш хэдэн цаг өнгөрснийг бүү мэд, Сэм, Фродо

хоёр таах гэж оролдсонгүй. Төгсгөлгүй шөнө үргэлжилсээр. Өмнө нь дахиад л ханан хад сүглийж, тэд шатанд хүрээд жаахан амарсны дараа мацаж эхлэв. Удаан өгссөн боловч шат уул руу нүхэлж орсонгүй, хадан хажуугаар могой мэт тахирлан, харанхуй ангалын ирмэгээр явахад тэртээ доор үхмэл цайзаас нэргүй даваа руу одсон бүдэг жим үзэгдэв.

Жим тахирлан үргэлжилсээр эцэст нь Эфель-Дуатын оргилд хүрэв. Хоёр талаар гүн хагархай ангалтай нүсэр цохионууд үргэлжилнэ. Тэнгэрт хүрэн улаан туяа харвасан нь нэг бол өглөө болж байгаа, нэг бол Саурон Горгоротыг улайран шатааж байгаа бололтой.

Фродо зогсч эргэн тойрныг харав. Зүүн талд хар цамхаг харагдав. Тэр Сэмийн ханцуйнаас татаж, цамхаг руу заав. Тэгээд Хорлум руу эргэж:

- Чиний нууц гарцыг хамгаалж байгаа юм шив дээ? Чи гайхахгүй байгаа биз?

- Энд гарцыг хамгаалдаг юм. Тэгэхгүй яах юм бэ! Гэвч хоббитууд хаа нэгтээгүүр нь гарах хэрэгтэй биз дээ? Энд арай сул хамгаалалттай байж магадгүй. Оролдоод үзэцгээ, бүгдээрээ дайнд явчихсан ч байж мэднэ!

- Оролдоод л үзье, тэр хүртэл хол байна, энд хүртэл ч бас хол байсан, дараа нь чиний гарц байгаа – гэж Сэм бувтнаад:

- Та жаахан амарсан нь дээр байх, эзэн минь. Өдөр ч юм уу, шөнө ч юм уу бүү мэд, бид хичнээн олон цаг гэлдэрлээ.

- Тийм шүү, амрах хэрэгтэй. Хаа нэгтээ салхинаас нуугдаж хөлөө амраагаад хөдөлбө – гэж Фродо зөвшөөрөв.

Уулын цаана ямар айдас хүлээж байгаа, тэнд очоод яахыг тэд мэдэхгүй. Гэхдээ тэр болтол зай ч байна, лай ч байна. Харин одоо тэдний өмнө давшгүй саад, сонор соргог харуулууд байна. Яаж ийгээд цаана нь гарна даа, тэгвэл бүх юм саадгүй бүтнэ гэж тэр бодов.

Хясаануудын дундах гүн хонхор оллоо. Фродо, Сэм хоёр нэлээд гүн орж, Хорлум үүдэнд цагариглав. Хоббитууд энэ насныхаа сүүлчийн хоолыг идэж байгаа юм шиг Гондорын хүнс, эльфийн талхаа сайтар идэж аваад ус балгав.

- Бид ус хаанаас авах юм бэ? Энд ус уухгүй бол мажийна биз дээ? Орхууд юм уудаг юм уу? – гэж Сэм асуухад:

- Уудаг, гэхдээ тэрийг яриад яахав, тэдний унд бидэнд зохихгүй – гэж Фродо хэлэв.

- Тэр тусмаа ус авах хэрэгтэй. Харин хаанаас ус олох вэ? Горхины дуу ч сонсогдсонгүй. Фарамир моргулийн уснаас битгий уугаарай гэж хэлсэн л дээ.

- “Имлад-Моргулаар урссан гол горхиноос битгий уугаарай” гэж тэр хэлсэн шүү дээ. Бид тэр хөндийг туулаад энд ирсэн. Булаг шанд таарвал ус авна аа – гэж Фродо хэлэв.

- Хашраас алдахгүй, гэхдээ цангаж үхэлтэй биш – гээд Сэм хамраа сартайлган үнэртсэнээ:

- Юу үнэртээд байна аа? Хачин өмхий, илжирхий юм шиг. Энэ ч надад огт таалагдахгүй байна шүү.

- Надад ч гэсэн. Салхи ч үгүй, чулуу ч үгүй, жим ч үгүй, ус ч үгүй. Одоо яая гэхэв, нэгэнт хүрээд ирснээс хойш.

- Тэр ч үнэн шүү. Хаашаа явж байгаагаа мэдсэн бол энд ирэхгүй л байлаа. Ер нь дандаа л ийм байсан байх даа. Жишээ нь эртний үлгэр домгууд байна. Үлгэрийн баатрууд зүгээр суухаас уйдаад адал явдал хайж, өөртөө зовлон авчирч байдаг. Үлгэр ч гэсэн бидний тухай л өгүүлдэг юм байна. Бид наашаа явахгүй байж болох л байсан. Яваагүй хүмүүс яасныг бид мэдэхгүй, яагаад гэвэл үлгэрт тэдний тухай өгүүлдэггүй. Явсан хүмүүсийн тухай л өгүүлдэг, тэд хүссэн газартаа ирдэггүй, сайнаар төгсвөл сайхан. Ноён Бильбо амьд мэнд эргэж ирээд, сайхан амьдарч байснаа дахиад л яваад өгсөн. Сайхан төгсгөлтэй үлгэрт орвол ч яахав! Харин бид ямар үлгэрт орчихсон юм бол доо? Тэр л сонин байна.

- Тийм ээ. Ёстой мэдэхгүй юм даа. Жинхэнэ үлгэрт бол үүнийг мэдэж ч болохгүй. Чи өөрийнхөө дуртай нэг үлгэрийг бодоод үз. Энэ үлгэр ямар үлгэр вэ, сайхан төгсгөлтэй юу, үгүй юу гэдгийг чи мэдэж байгаа, наанадаж таамаглаж байгаа. Гэтэл үлгэрийн баатар тэрийг огт мэдэхгүй. Мэдлээ гээд чамд ямар ч хэрэггүй.

- Мэдээж хэрэггүй эзэн минь. Нөгөө Берен гэхэд л төмөр титэмнээс Сильмарилл олно гэж бодоо ч үгүй байсан, гэтэл Тонгородримд яваад хүрчихсэн. Эндхээс ч цэвэрхэн газар л даа. Гэтэл тэр тухай уртаас урт үлгэр байдаг. Баяртай ч юм болно, гунигтай ч юм болно, төгсгөл нь огт төгсгөл биш. Сильмарилл дараа нь Эарендилийнх болсон. Тэр Сильмариллын гэрэл хатан хааны танд бэлэглэсэн болор аяганд байгаа шүү дээ! Тэгэхлээр бид хоёр ч гэсэн тэр үлгэрт байгаа биз дээ! Тийм үлгэр хэзээ ч төгсдөггүй юм болов уу?

- Тийм ээ, төгсдөггүй юм. Үлгэрийн баатрууд л солигдоно, ирээд л, яваад л өгнө. Бид хоёр ч гэсэн эрт орой хэзээ нэгэн цагт яваад өгнө, эрт л явах нь шиг байна даа.

- Явна аа, амарна, унтаж авна – гээд Сэм гунигтай инээж:

- Би тоглоогүй шүү эзэн минь. Хаа нэгтээ биш, гэртээ амарна. Сайхан унтаж аваад, өглөө цэцэрлэгтээ ажиллана. Надад энэ л хэрэгтэй. Баатарлаг гавьяа байгуулдаг нь байгуулдаг л юм байгаа биз, надад ямар хамаа байна. Харин бид хоёр үлгэрт ордог болов уу, дуунд ордог болов уу, тэр л сонин байна. Мэдээж бид одоо ч гэсэн үлгэрт орчихсон байгаа. Олоон жилийн хойно үдэш оройн цагаар задгай зуухны дэргэд суугаад сонсдог ч юм уу, улаан, хар бичигтэй томоо гэгч номноос уншдаг ч юм уу. Аав минь хажууд суугаад: “За хө, Фродогийн тухай, бөгжний тухай уншина аа!” гээд л. Хүү нь тэгэхээр: “Тэгье аав аа, миний хамгийн дуртай түүх! Фродо гарамгай зоригтой баатар, тийм ээ, аав аа?” гэнэ. Аав: “Тийм ээ, миний хүү. Тэр бол дэлхий дээр хамгийн алдартай хоббит, чамд энийг хонь найтааж байгаа юм биш!” гэнэ дээ.

- Хонь гэдэг чинь ёстой үнэн - гээд Фродо чин сэтгэлээсээ цангинатал инээв. Саурон Дундад газарт ирснээс хойш энд ийм инээд сонсдож байсангүй. Энэ инээдийг бүх чулуу, бүх хясаанууд сонсч байгаа юм шиг Сэмд санагдав. Фродо дахин инээгээд:

- За Сэм минь, чи ёстой жинхэнэ инээд хүргэчихлээ. Би тэр үлгэрийг өөрөө уншчихсан юм шиг л боллоо. Гэвч чи хамгийн гол баатар –аймшиггүй Сэммиумын тухай нэг ч үг хэлсэнгүй. “Аав, би бас Сэмийн тухай сонсмоор байна. Аав, тэр яагаад ийм бага ярьдаг юм бэ? Тэр их инээдтэй ярих юм. Фродо Сэмгүйгээр хаа ч хүрэхгүй байсан биз дээ? Тийм үү, аав аа?”.

- Эзэн минь, би үнэнээсээ ярьж байхад та тоглоом болгочих юм даа.

- Би ч гэсэн үнэнээсээ ярьж байна. Үүнээс илүү үнэн гэж юу байх вэ. Харин бид хоёр төгсгөлийг нь алгасаад хамгийн аймшигтай газар нь ирчихлээ. Хэн нэг нь: “Аав аа, номоо хаа, цааш нь унших хэрэггүй” гэж хэлэх биз.

- Мэдэхгүй юм даа, миний хүүхдүүд бол тэгэж хэлэхгүй. Үлгэрт бүх юмыг багтаадаг болохоор түүнд Хорлумыг ч оруулах хэрэгтэй. Тэр хоёр зуун жилийн өмнө үлгэрт дуртай байсан юм шиг санагдах юм. Тэр өөрөө юу гэж бодож байгаа юм бол? Баатар юм болов уу, хорон санаат шулам юм болов уу? Хөөе, Хорлум! Баатар болохыг хүч байна уу?.. тэр хаашаа алга болчихов оо?

Тэр байсан газраа ч алга, ер нь ойр хавьд алга. Тэр хоолноос ам хүрээгүй, ус балгачихаад л цагариглаад өгсөн билээ. Урьд нь бол ч яахав, хорхой шавьж ч хамаагүй барьж идэх гээд явдаг байсан, гэтэл энд ямар ч амьтан байхгүй.

- Тэр чимээгүй алга болчих юм, юугаа хийж явдаг юм бол? Энд барьж идэх амьтан байхгүй, ухаж малтах ч юм байхгүй дээ. Амттай чулуу олсон юм болов уу? Хөвд ч олдохгүй шүү дээ!

- Түүнийг тайван орхи, тэр байгаагүй бол бид хоёр энд насандаа дөхөж ирэхгүй байсан. Тэр өөрийнхөө байгаагаар л байх болно.

- Гэлээ ч гэсэн тэр нүдэнд харагдаж л байвал надад тайван байдаг юм. Тэр цамхаг нэг бол хоосон, нэг бол дүүрэн орхууд ч юм уу, хэн ч юм байгаа. Тэдэн рүү явчихсан юм биш байгаа?

- Үгүй байлгүй дээ. Тэр нэг юм сэдсэн бол орхууд ч юм уу, Дайсны бусад зарц нар үүнд хамаагүй. Тэгвэл яах гэж ингэж их хүлээж, бид хоёрыг энд дагуулж ирэх билээ? Тэр өөрөө энэ хязгаараас үхглээ айж байгаа. Бид уулзсанаас хойш тэр бид хоёрыг зуун удаа бариад өгчих болсон. Тэр ямар нэг юм сэдсэн бол өөрийнхөөрөө чимээгүй хийж байгаа.

- Таны зөв өө, эзэн минь. Гэхдээ л би баярласандаа босч харахгүй. Тэр намайг одоо ч гэсэн баастай минь хамт зарчихна. Бүр нэмэр өгөөд зарна. Би мартчихаж, нөгөө эрдэнэ! Бүр эхнээсээ л тэрний духан дээр: “Эрдэнийг минь хөөрхий Смеагорлд өг!” гээд биччихсэн байсан юм. Тэр нэг юм сэдсэн бол энэ талын л юм байгаа. Харин яах гэж бид хоёрыг нааш нь дагуулж ирснийг ёстой чөтгөр л мэдэх байх.

- Яах гэж гэдгээ тэр өөрөө ч мэдэхгүй байгаа. Тэрний толгойд ямар нэг бодол тогтохгүй л болов уу. Зүгээр л эрдэнээ Дайснаас чадах чинээгээрээ хамгаалж байгаа байх. Тэр эрдэнийг нь авчих юм Хорлум байхгүй болно шүү дээ. Түүнээс гадна боломжтой тохиолдлыг хүлээж байгаа.

- Тийм ээ, миний хэлдгээр Өмхий, Зангуу хоёр. Дайсны газарт ойртох тусам Зангуунаас улам их өмхий гараад байгаа юм. Миний үгийг санаж яваарай, тэр магтаад байгаа гарцандаа хүрмэгц тэр эрдэнээ тавихгүй шүүрнэ шүү.

- Тэр болтол амьд байх хэрэгтэй.

- Амьд байхын тулд сэрэмжтэй л байх хэрэгтэй. Зүүрмэглэх л юм бол Өмхий боломжийг алдахгүй. Би өөртөө ингэж хэлж байгаа юм. Та одоо жаахан унтаж намайг баярлуул. Харин намайг налж унтана шүү. Би таныг хамгаална.

- Унтах! – гэж Фродо хэлээд элсэн цөлд яваа аянчин сэрүүхэн ногоон зэрэглээ харсан мэт санаа алдаж:

- Сайн харж байгаарай, тэгэхгүй бол би үнэхээр энд ч гэсэн унтчих юм байна.

- Унт унт, эзэн минь! Миний өвдгөн дээр дэрлээд унт!

Хорлум хэдэн цагийн дараа дөрвөн хөллөн гүйсээр ирэв. Сэм суугаагаараа, хацраа мөрөндөө наан, нэгэн жигд гүнзгий амьсгалж байв. Фродо түүний өвдгийг дэрлээд нам унтаж байв. Сэм нэг гараа түүний духан дээр, нөгөө гараа цээжин дээр нь тавьжээ. Хорлум тэр хоёрыг хармагцаа нүүр нь нэг л хачин болов. Нүднийх нь харц махчин амьтных шиг гал бөхөж, ихэд өвдсөн юм шиг давхийгээд, давааны зүг харж, зэмлэсэн юм шиг толгой сэгсрэв. Дараа нь тэр хоёрт дөхөж ирснээ чичирсэн гараараа Фродогийн өвдгийг зөөлөн илэв. Хэрэв унтаж байгаа хоёр түүнийг харах юм бол зөнөж үхэх гэж байгаа золгүй хоббит шиг харагдах байв. Түүний гар хүрэхэд Фродо аяархан хөдөлж, нойрон дундаа аяархан дуу алдахад Сэм нүдээ нээж, “Эзэн рүү сарвуугаа явуулсан” Хорлумыг хамгийн түрүүнд харав.

- Хөөе чи! Юу хэрэгтэй вэ? – гэж тэр зандрав.

- Зүгээр зүгээр, сайн эзэн!

- Сайн нь ч сайн л даа. Харин чи хөгшин хорон санаат хаашаа алга болчихов?

Хорлум давхийн зайлж, хүндэрсэн зовхин дороос нь ногоон оч гэрэлтэв. Тэр яг аалз шиг бөгтийн дөрвөн хөллөж, нүд нь аяганаасаа бүлтрэх шахаж харагдав. Саяхны уянгын хором огт байгаагүй юм шиг алга болжээ.

- Алга болчихов! Хоббитууд бүгдээрээ ийм эелдэг зантай юу? Хххөөрхөн хоббитууд! Смеагорл тэднийг нууц гарцан дээр авчирсан. Тэрнийг хэн ч мэдэхгүй. Тэр их ядарсан, уухыг хүссэн, тийм ээ, тэр өчнөөн явж, жим хайсан. Эргээд ирэхээр нь: “Хаашаа алга болчихов” гэнэ ээ. Мөн ч сайн найз нар юм даа, тиймээ эрдэнэ минь, сайн найз нар.

Сэм жаахан ичсэн боловч сайхан зантай болсонгүй:

- За уучлаарай. Нойрон дундаа юу ч хэлж мэднэ шүү дээ. Би унтаж болохгүй, гэвч жаахан зүүрмэглэчихлээ. Эзэн их ядарсан, тэгээд л би жаахан унт гэсэн юм. Би хамгаалах ёстой байтал өөрөө зүүрмэглэчихэж. Уучлаарай, чи хаачаад ирэв?

- Алга болоод ирлээ – гээд Хорлумын нүд ногоон оч гялалзуулав.

- За тийм бол өөрөө мэд. Би тийм ч их алдаагүй юм байна. Одоо ямар ч гэсэн гурвуулаа байна. Хэдэн цаг болж байгаа бол? Өнөөдөр юм уу, маргааш юм уу?

- Маргааш болсон. Хоббитуудыг унтаж байхад маргааш болсон. Энд унтаж болохгүй, унтах аюултай, хөөрхий Смеагорл тэднийг хамгаалж алга болоод л.

- Үгнээс зуураад тавихгүй нь ээ, одоо болно. Эзнийг сэрээ – гээд Сэм тонгойж Фродог аяархан дуудав:

- Сэрээрэй эзэн минь, босоорой!

Фродо нүдээ нээж, Сэмийг хараад инээмсэглэв:

- Арай эрт сэрээж байгаа юм биш үү аа, Сэм? Харанхуй байна шүү дээ!

- Энд үргэлж харанхуй байдаг шүү дээ. Хорлум эргэж ирсэн, маргааш болсон гэж байна. Явах хэрэгтэй.

Фродо гүнээ санаа алдаад өндийж суув.

- Тэгье ээ! Сайн уу, Смеагорл! Идэх юм олов уу? Амрав уу?

- Смеагорлд амрах, идэх зав байхгүй. Тэр алга болсон, тэр алга бологч.

Сэм тагнай ташсан боловч юм хэлсэнгүй

- Өөрийгөө битгий элдвээр хэл, Смеагорл, хэлэх ёстой байсан ч ингэх муухай - гэж Фродо хэлэв.

- Смеагорл өөрийгөө элдвээр хэлээгүй, түүнийг ухаантай хоббит, элддэг ноён Сэммиум элдвээр хэлж байна.

Фродо Сэм рүү харав.

- Тийм ээ эзэн минь, би зүүрмэглээд сэрэхдээ тэгж хэлсэн юм. Уг нь би уучлал гуйсан юмсан, дэмий л юм болсон шиг байна.

- Маргалдах цагаа олов оо. Чи намайг хэлсэн газраа хүргэж ирсэн, Смеагорл. Цаашаа бид хоёр өөрсдөө явна, тийм биз дээ? Хаашаа явах нь ойлгомжтой, даваа харагдаж байна. Хэрэв тэнд юу ч тааралдахгүй бол чи хийдгээ хийсэн, хэлсэн амандаа хүрсэн. Чи одоо чөлөөтэй, дуртай зүг рүүгээ яв, харин дайсны зарц нар руу явахгүй шүү. Идэж ууж, амарч ав. Чамайг би биш гэхэд, намайг мэдэх хэн ч шагнана.

- Үгүй үгүй, тэр хоёр цаашаа өөрсдөө явна гэв үү? Үгүй ээ, явахгүй. Гарц их хэцүү. Смеагорл тэдэнтэй явах хэрэгтэй. Идэж ч болохгүй, унтаж ч болохгүй, түүнд юу ч болохгүй.

Одоохондoo үгүй.

Бүлэг 19

Шелобын ичээ

Хорлумын хэлснээр өдөр болсон ч байж магадгүй, гэвч хоббитууд өдрийн ямар ч шинж тэмдэг харсангүй. Тэр хоёр Хорлумын араас салхинд элэгдсэн чулуун багана шиг юмнуудын хоорондох хавцлаар зэрэгцэн явж байв. Эргэн тойронд нам жим. Урд талд нь нэг бээр орчим зайд аварга том эгц хадан хясаа сааралтаж харагдана. Хясаа ойртсоор тэнгэр, газрыг өндөр хар хана болон хаав. Сэм агаар үнэрлэж үзээд:

- Түй! Ямар өмхий юм бэ! Ухаан алдмаар юм - гэлээ.

Харанхуй улам өтгөрч, хясааны хананд агуйн ам харлан онгойж харагдав.

- Ийшээ орно, эндээс гарц эхэлдэг юм – гэж Хорлум хэлэв. Тэр агуйн нэрийг хэлсэнгүй. Уг нь Торек-Унгол буюу Шелобын ичээ гэдэг ажээ. Тэндээс баахан ялгадас овоолон ялзруулсан юм шиг тэсэхийн аргагүй муухай өмхий ханхалж байв.

- Энэнээс өөр гарц байхгүй юу, Смеагорл? – гэж Фродо асуув.

- Байхгүй, байхгүй, зөвхөн энэ. Цөмөөрөө одоо энэ рүү орно.

- Чи энэ нүхээр шургаж байсан юм уу? Чамд ямар ч өмхий юу ч биш л дээ, мартчихаж – гэж Сэм үг нэмэрлэв.

Хорлумын нүд хорсолтой гялсхийлээ.

- Бидэнд энэ үнэр хэцүү гэж тэр мэдэхгүй л дээ, тийм үү, эрдэнэ минь? Тэр юу ч мэдэхгүй. Зүгээр л Смеагорл машшш их тэвчээртэй.

- Юу үнэртээд байгаа юм бэ? Түй, энд орхууд баадаг биз, зуун жил хураагдаад одоо... түй – гэж Сэм хэлэв.

- Орх ч байна уу, биш ч байна уу ялгаагүй, өөр зам байхгүй.

Тэд амьсгаа дараад агуй руу оров. Хэдхэн алхаад тас харанхуй болов. Фродо, Сэм хоёр Мориугоос хойш ийм харанхуйд орж байсангүй. Мориид ямар ч гэсэн салхи үлээж, цууриа сонсогддог байсан бол энд агаар нь хөдөлгөөнгүй, хүнд, нэхширсэн учир чимээ сонсогддоггүй ажээ. Энд нүд хорсох төдийгүй ой ухаан балартаж байв. Тэр хоёр гараа сунган тэмтэрч маш болгоомжтой гишгэж байв. Хана нь гөлгөр, шал нь тэгшхэн ажээ. Нэлээд өргөн учир хоёр хоббит гараараа хана тулан явахдаа бие биеэсээ төөрчихүйн тулд зэрэгцэж явахыг хичээж байлаа. Хорлум түрүүлж явсан бөгөөд шуухитнах нь сонсогдож байснаа сүүлдээ юу ч сонсогдохоо болив. Цаг хугацаа хүртэл харанхуйд ууссан юм шиг санагдана. Сэм хана тэмтэрч яваад баруун талд нь бас нэг нүх байгааг олов. Тэндээс бараг салхи үлээх шиг санагдсан боловч цааш явлаа.

- Энд ганц гарц байдаггүй юм байна. Орхууд л амьдарч, жаргаж баймаар газар байна даа – гэж тэр ихэд хичээн байж шивнэв.

Дараа нь дахиад гурав дөрвөн нүхэн цооног тааралдсан боловч хонгил салаалсангүй. Эцэс төгсгөлгүй тэр хонгил дуусч өгдөггүй, тэр хоёрын тэвчээр барагдаж байв. Цаашлах тусам улам л их өмхий ханхална. Хэдэн цаг, хэдэн өдөр явснаа ч мэдэхээ болив. Тэр хоёрын бүх мэдрэхүйгээс ганцхан үнэрлэх мэдрэхүй л тэднийг тамлахын тулд үлдсэн юм шиг. Сэм баруун хананаас салж, Фродогийн гараас барин урагшиллаа. Фродогийн зүүн талд гэнэт нэлээд өргөн нүх гарч ирсэн тул тэр рүү уначих дөхөв. Тэндээс бүр ч аймшигтай муухай өмхий үнэртсэн учир тэр бараг ухаан алдах шахав. Сэм бүдэрч, түрүүлгээ харан уналаа. Фродо гараас нь зууран:

- Босоорой! Эндээс өмхий гарч байна, үхэл ч үнэртэж байна. Ургашаа! Түргэл! – гэж арайхийн хэлэв.

Тэр хамаг хүчээ шавхан Сэмийг татаж босгоод урагшаа ухасхийлээ. Сэм гуйван байж зургаа алхахад ямар нэг цооног өнгөрсөн юм уу, явахад арай хөнгөн болсон тул урьдын адил гараасаа хөтлөлцөн гэлдрэв. Гэтэл хонгил гэнэт хэдэн салаа болов. Харанхуйд аль нь өргөн, аль нь шулуун болохыг мэдэх аргагүй бөгөөд бурууг нь сонговол гарцаагүй үхэл рүү очих байлаа.

- Хорлум хаачив? Тэр яагаад хүлээхгүй байна? – гэж Сэм шивнэв.

- Смеагорл! – хэмээн Фродо дуудсан боловч ямар ч чимээ алга.

- Энэ удаа тэр бүрмөсөн зугтаачихлаа. Энд л авчрах гээд байж л дээ. Хорлум! Тааралддаг юм бол толгойг чинь тасдана даа! – гэж Сэм хэлэв.

Алхам тутамдаа бүдрэн байж тэмтэрч үзэхэд зүүн хонгил мухар юм шиг байв.

- Энэ биш байна. Тэгэхээр сонголт алга. Зөвхөн өөр ганц хонгил байвал тийшээ л орёе, юу л болвол болог – гэж Фродо хэлэв.

- Хурдан буцъя! Нэг амьтан бид хоёрыг хараад байна. Хорлум л лав биш – гэж Сэм хэлэв.

Өөр хонгил олоод хоёр мод газар ч гүйгээгүй байтал араас нь уухилах, урхирах, сийгүүлэн исгэрэх сонсогдлоо. Эргэж хартал юу ч үзэгдсэнгүй. Хоббитууд үл мэдэгдэх этгээдийн дайралтыг хүлээн зогсов.

- Энэ урхи байна! - гэж Сэм хэлээд илдээ шүүрэхдээ булшны нүхнээс аврагдсанаа санав. “Ээ чааваас, Том энд ирдэг ч болоосой!” гэж тэр бодлоо. Гэвч Том даанч хол байлаа. Уурлаж, цөхөрсөндөө зүрх нь агших шиг болов. Гэнэт түүний дотор гэрэл асч, тэгснээ асар хурцаар цацран гэрэлтлээ. Гэрэл ногоон, алтан шаргал, мөнгөлөг, цагаанаар солонгоров. Тэртээ алсад, яг эльфийн зураг дээр байгаа юм шиг хатан хаан Галадриэль Лориэний ногоон зүлгэн дээр зогсч, гарт нь бэлэг харагдав. “Хадгалагч минь, чамд би сүүлчийн эрдэнээ бэлэглэж байна” гэж хичнээн их холоос тов тодхон хэлэхийг сонслоо.

Бүр хажууханд нь ямар нэг олон үет хөлтэй өмхийгөөр тургисан амьтан удаанаар хөдөлж байгаа юм шиг уухилах, урхирах, сийгүүлэн исгэрэх харанхуй дундаас сонсогдлоо.

- Эзээн, эзээн! Хатан хааны бэлгийг! Гэрэлт аяга! Харанхуйг гэрэлтүүлнэ гэсэн шүү дээ!

- Гэрэлт аяга аа? Нээрэн тийм л дээ! Би яагаад мартчихав аа! Хичнээн харанхуй байвал төчнөөн хурц гэрэлтэнэ! -гэж Фродо нойрон дундаа юм шиг бувтнаад өврөөсөө Галадриэлийн аягыг гаргаж толгой дээрээ өргөв. Аяга бүдэгхэн гэрэлтсэнээ харанхуйг үлдэн хөөж, Эарендил өөрийн биеэр, Сильмариллаа магнай дээрээ мандуулан орж ирэх шиг хурц мөнгөлөг гэрлээр хонгилыг дүүргэж, Фродогийн гар дээр нүд гялбам цагаан очис цацруулав.

Ямар ч хэрэггүй мөртөө үнэ цэнэтэй бэлэг мэт замын турш нандигнан хадгалж явсан хатан хааны бэлгийг Фродо гайхан харлаа.

- Айяа Эарендил Эленион Анкалима! – хэмээн тэр хашгирахдаа ийм үг хаанаас толгойд нь орсон, ямар утгатайг ч мэдэхгүй байв. Энэ үгийг түүний амаар өөрийнхөөс нь огт өөр, өмхий харанхуйг хага ярсан тод чанга дуу цууриатуулалаа.

Өмхий цооногоос үй олон нүд нийлэн бөөгнөрсөн хоёр бөөрөнхий гарч ирээд аяганы хурц гэрлийг ойлгов. Аалзных мөртөө аалзных биш тэр нүднүүд үхлийн цагаан гэрэл, хэмжээлшгүй их хорсол заналыг дотроосоо цацаж байлаа. Фродо, Сэм хоёр тэр нүднээс хараа салгалгүй ухрахад нүд улам ойртов. Фродогийн гар суларч, гэрлээ удаан буулгав. Тэгээд хоёулаа зугтан гүйв. Фродо мөрөн дээгүүрээ эргэж хартал нүд араас нь харайж байлаа. Өмхий үнэр түүнийг үхэл мэт тушив.

- Зогс! Зогс ! Энэнээс зайлж болохгүй юм байна – гэж тэр хашгирлаа. Нүд аажмаар ойртов.

- Галадриэль! – хэмээн Фродо дуудаад, эр зориг гаргаж, аягаа дахин өргөв. Нүд дороо зогсч, эргэлзэж байгаа мэт гэрэл нь унтрав. Фродогийн зүрх уур хилэн, бахархлаар дүүрч, аягаа зүүн гартаа бариад, баруун гараар илдээ сугаллаа. Найдвартай, хурц илдний ир мөнгөлөг гэрэлд гялалзан, цэнхэр очис цацруулав. Эльфийн гэрлийг өргөж, очис цацруулсан илд сунгасаар Хоббитаний бяцхан хоббит Фродо Торбинс аалзны нүд рүү алхлаа. Нүд бүр унтарч, өөдөөс нь дөхөж байгаа ер бусын хурц гэрлээс ухрав. Асар том пэндгэр амьтан хонгил руу далд оров.

- Эзээн, эзээн! - хэмээн Сэм түүнээс хоцролгүй илдээ сугалан явж байгаа мөртөө чанга дуудаж:

- Уухай, бидний алдар бадраг! Эльфүүд энэ тухай сонсвол тэр дор нь дуу зохионо доо. Би амьд гарвал тэдэнд ярьж өгөөд, дууг нь сонсоно оо. Гэвч цаашаа явж хэрэггүй, эзэн минь! Тэрний ичээ рүү орж хэрэггүй! Энэ өмхий нүхнээс хурдан гарья!

Тэгээд хонгилоор буцаж гүйлээ. Тэндээс эгцхэн өгсч, өмхий үнэр улам сулран, зүрх жигдхэн цохилж, хөл нь өөрөө л гүйгээд байв. Эцэст нь хүйтэн агаар сэвэлзэж, хонгилын нөгөө үзүүр харагдлаа. Тэр хоёр ухасхийн гарах гэтэл нэг юм мөргөж гэдрэг шидэгдэв. Босоод хартал гарцыг пүрш шиг уян мөртөө гэтлэхийн аргагүй юмаар хаасан байв. Гаднаас агаар орж, гэрэл

дөнгөж нэвтэрч байлаа. Мань хоёр дахин дайрсан боловч дахин шидэгдэв.

Фродо гэрлээ өргөж харвал бүдүүн олсны дайтай аалзны шүлсэн тор хонгилын гарцыг хаасан байв. Сэм инээж:

- Аалзны тор л байна шүү дээ! Ердөө л энэ үү? Тас цавчаад хаяъя!

Тэгээд илдээ далайн цавчтал аалзны шүлс тасарсангүй. Харин нум шиг хөвчрөн тавигдаж, илдийг буцааж ойлгов. Сэм байдаг хүчээрээ гурван удаа цавчихад ганц ширхэг нь тасарч, агаарт исгэрэн эрчлээд Сэмийн гар руу шилбүүрдэв. Сэм өвдсөндөө дуу алдан хашгирч алхам ухраад гараа үлээлээ:

- Ийм байдлаар долоо хоногт ч тасалж дуусахгүй юм байна. Одоо яах вэ? Нөгөө нүд харагдана уу?

- Харагдахгүй байна, гэвч намайг тавихгүй байна. Нүд биш, санаа нь бололтой. Хурдан нэг арга бодож байна. Гэрэл унтармагц л гараад ирнэ.

- За ингээд аалзны шүлсэнд наалдсан шумуул болдог байжээ! Тэр Хорлум дэлбэрч үхээсэй! Фарамир тэрэнд түргэн үхэл амласан. Түргэн биелээсэй!

- Тэглээ гээд бид хоёрт ямар ашиг байна? Алив, Тернээрээ нэг үзье, ямар ч гэсэн эльфийн илд байна даа, энэ илдийг давтсан Белериандын харанхуй хавцалд иймэрхүү аалзнууд байсан гэсэн. Чи нөгөө нүд гараад ирвэл хөөж бай, май гэрэл ав, бүү ай. Сайн харж байгаарай!

Фродо торонд дөхөж очоод илдээ далайн хүчтэй буулгангуутаа үсрэн зайлав. Гялалзсан цэнхэр ир торыг хадуураар өвс хадах мэт тас хяргаж унжууллаа. Фродо торыг бүрэн унатал цавчсаар байлаа! Урхинаас гарлаа.

- Явъя! Түргэлээрэй!

Үхлийн аман дотор ороод гарсандаа Фродо туйлгүй ихээр баярлаж байлаа. Том аяга дарс залгилсан юм шиг толгой нь эргэв. Тэгээд хашгиран гүйж гарлаа.

Өмхий хар нүхнээс гарч ирэхэд харанхуй хязгаар түүнд гэрэлтэй мэт санагдав. Хэрмийн орой дэргэд байна. Дахиад жаахан өгсөхөд л Кирит-Унгол руу орлоо. Хэдхэн хайрайгаад л цаад талд нь гарчихна!

- Даваа энэ байна, Сэм! Даваа өөд! Гүйгээд л гарчихна, бид хоёрыг саатуулж чадахгүй! – гэж цоглог чанга дуугаар өөрөө ч мэдэлгүй хашгиран ухасхийлээ. Сэм араас нь байдаг хурдаараа гүйж байхдаа сонор сэрэмж алдсангүй, эргэж хартал нөгөө нүд төдийгүй аалз бүтнээрээ гараад ирвэл яана! Тэр хоёр Шелобын ичээг мэддэггүй байжээ. Тэндээс нэг биш, хэд хэдэн гарц байдаг аж. Шелоб энд диванггарын үеэс энд оршиж байгаа бөгөөд аалзны дүрд хувилсан хар хорын бөөгнөрөл байв. Ийм амьтад эртний эльфүүдийн оронд байсан ба тэнгис тэднийг залгижээ. Берен Аймшгийн ууланд ийм амьтантай тулалдсан бөгөөд уулнаас бууж ирэхдээ ногоон нугад, сарны гэрэлд бүжиглэж буй Лучизэнийг олж харсан байна. Шелоб мөхсөн

хязгаараас яаж амьд гарч, энд ирсэн тухай домогт өгүүлээгүй ажээ. Гэвч тэр Сауроныг ирэхээс хамаагүй өмнө ирсэн бөгөөд эльфүүд болон хүмүүсийн цусыг сорон таргалж өөхөлсөөр, харанхуйгаар бөөлжсөөр өдий хүрчээ.

Хэдэн жилийн өмнө хар нүх болгоноор шургагч Хорлум-Смеагорл тэрэнтэй учирч, амь гуйн залбирч мөргөхийн хамт хар хороор нь ундаалжээ. Тэгээд тэрэнд хоол авчирч өгөхөөр амласан байна. Гэвч тэр хоёрын хүсэл зорилго өөр өөр байв. Аалзанд ертөнц дээр юу ч болж байсан хамаагүй, зөвхөн амьд бүхнийг алж, амьдралын шүүсийг нь сорохын шуналд автсан байлаа.

“Харжжж л байя, тэр амттай шүүсийг нь сорчихоод яссс масссыг нь хаячихаар би эрдэнээ эрж олоод авччихна. Амттайхан хоол авчирч өгсөн хөөрхий Смеагорлд хариу бэлэг болог. Тэгээд бид эрдэнээ тангараг өргөснийхөө дагуу нандигнана. Тэгээд ... бид тэрэнтэй тооцоо хийнэ, эрдэнэ минь. Бид бүгдтэй нь тооцоо хийнэ!” – гэж Хорлум бодож байлаа. Энэ бодлоо ходоодныхоо мухарт нуусан Хорлум хоббитуудыг нам унтаж байх хойгуур аалзанд очиж дахин мөргөжээ.

Саурон аалзыг хаана нуугдаж байгааг мэдэж байлаа. Түүнд тэрний өлсгөлөн шунал, хар хор хоёр тааламжтай бөгөөд чухал байв. Эртний энэ даваанд тэрнээс илүү манаачийг хаанаас ч эрээд олохгүй билээ. Орхууд найдвартай гар хөл боловч Сауронд юу л байна, орхууд л байна. Шелоб сайхан цагаа иртэл амт муутай боловч хямдхан орхуудаар хооллож л байг. Хааяа тэрэнд амттай хоол хаяж өгнө. Саурон хоригдлуудыг тарчилган тамласны дараа Шелобын нүх рүү хаядаг, тагнуулууд нь тэр яаж тансагласныг дараа нь мэдээлдэг байлаа.

Хөөрхий Сэм ийм аймшигт мангасын талаар юу ч мэдэхгүй байсан бөгөөд зөвхөн төрөлхийн совингоороо залахын аргагүй үхлийн аюул улам ойртсоор байгааг л мэдэрч байв. Тэр айдсаас салж чадсангүй. Даваан дээр дайснууд хүлээж байгаа, гэтэл эзэн баярланихсан гүйгээд байдаг. Толгой нь хаанаа байна аа? Хясааны зүүн талын онгорхой хар агуй, өтгөн харанхуй руу хараад тэр бүр ч их түгшив. Фродогийн илд цэнхэр галаар дүрэлзэж, цамхагийн цонх улайран гэрэлтэж байв.

- Орхууд! Дүүрэн орхууд байна – гэж тэр бувтналаа. Тэгээд хамгаас үнэт аягаа алгаараа дарахад гар нь амьд цусны халуун гэрлээр дүүрч, аягаа энгэрийн халаасандаа хийгээд цуваа товчлов. Яарах хэрэгтэй байлаа. Эзэн нь энэ хооронд холдож, хориод алхмын цаана саарал цув нь бүртэлзэж байна. Хар мананд үзэгдэхгүй болвол яана!

Сэм аягаа дөнгөж өвөртлөнгүүт аалз гараад ирэв. Нөгөө хар агуйгаас аймшигт зүүдний мухраас гарч ирж байгаа юм шиг харахын аргагүй ой гутам муухай амьтан гарч ирлээ. Аалз шиг л аалз харагдавч, ямар ч араатнаас том, харваас зэвүүн, нүд нь хайр найргүй шуналаар асч үзэгдэв. Асар бүдүүн хүзүүнээс нь эвэртэй толгой цухуйж, үлээсэн гүзээ шиг их бие нь олон үетэй найман хөлнийхөө дундуур цэлцэгнэн, нуруу нь хөхөвтөр толбоор дүүрэн, гэдэс нь цайвартан өмхий ханх тавина. Нууруунаасаа дээш гарсан хөлнүүд нь бүгд хавчууртай ажээ.

Тэр олон үеэ нужигнуулан асар хурдан гүйх бөгөөд Фродо, Сэм хоёрын хоорондуур орж ирэв. Тэр Сэмийг анзаараагүй юм уу, гэрэлт аягагүй болсон Фродог яасан ч алдахгүй гэсэн юм уу

түүний араас харайлгав. Фродо эргэж харалгүйгээр хөлийн хурдаар гүйж байв. Гэвч Шелоб хамаагүй хурдан ойртож байлаа. Гурав харайхад л гүйцэх нь гэж Сэм мэдэнгүүт байдаг хоолойгоороо хашгирав:

- Эргээрэй! Эргээрэй эзэн! Би одоохон...

Гэвч дуу нь тасарлаа.

Түүний амыг урт хуруутай, наалдамхай гар даран авч, өөр нэг гар хүзүүгээр нь ороогоод, хөлийг нь дэгээдэхэд тэр түрүүлгээ харан унав.

- Баригдав уу! Эцсийн эцэст бидэнд баригдав ишшив, зззэвүүн муухай одой! – хэмээн Хорлум чихэнд нь сийгүүлээд:

- Тийм ишшүү! Бид энэнийг багалзуурдана. Нөгөөтөх нь Шелобын хоол болно. Бид тэрэнд гар хүрэхгүй. Тэр Шелобт ногдоно. Харин Смеагорл тангаргаа биелүүлнэ, эзэндээ огт гар хүрэхгүй. Смеагорлд чи ногдоно, муу зэвүүн муухай санаат! – гээд тэр Сэмийн хүзүү рүү нулимав.

Адгийн муухай урвалтаас болж эзэн нь үхлийн аюулд өртчихөөд байхад санамсаргүй алдаа гаргасандаа дэлбэртлээ уурласан Сэм гэнэт ер бусын их хүчтэй болов. Хорлум өөрөө ч гэсэн ийм ихээр улайрч, ийм гавшгай хөдөлж чадахгүй билээ. Сэм тэрний гарыг амнаас хуу татаад, бөхийн бухаж, хүзүүнээсээ нөгөө гарыг нь салгахыг шахав. Баруун гарт нь илд, зүүн гарт нь Фарамирын таяг байлаа. Сэм эргэж, Хорлумыг бүлэх гэтэл цаадах нь бугуйг нь бахь мэт чанга атган мушгилаа. Сэм өвдсөндөө хашгираад илдээ алдах мөчид хоолойг нь улам хүчтэй шахав.

Тэгмэгц Сэм хүчээ хурааж, нэгэнтээ бөхөсхийгээд, хөлөөрөө газарт бат тулж, хамаг хүчээрээ гэдэргээ савав. Энэ энгийн мэхийг гэнэт хурдтай хийсэн тул Хорлум нуруугуураа газар алгадан унаж, Сэм дээр нь гарлаа. Бүдүүн хоббит түүний элгэн дээр нуруугаараа унахад хорлум хорсолтой сийгүүлээд, хоолой базсан гар нь суларсан боловч баруун гарыг нь тас атгасан хэвээр байлаа. Сэм ухасхийн эргэж, хүзүүгээ суллаж аваад, үсрэн босч, баруун гараас нь зүүгдсэн хорлумыг хүчтэй түлхэнгүүт таягаараа гар руу нь буулгалаа.

Хорлум гомдолтой гэгч муухай хашгиран гараа тавихад Сэм таягаараа дахин буулгатал толгойг нь оносонгүй, нуруун дээр нь тасхийн бууж, таяг хуга үсрэв. Хорлум араас дайрахдаа гаргуун мэргэшсэн боловч энэ удаа хар хорсол нь тэрнийг хөөджээ. Шууд л хоёр гараараа багалзуурдах ёстой байжээ. Бүгдийг сайтар бодож, нарийвчлан төлөвлөсөн байтал хараал идсэн тэр муу гэрэл бүгдийг баллаж орхих нь тэр. Одоо хүчээр бараг тэнцүү, хилэгнэсэн дайсантай халз тулалдах боллоо. Тэр угаасаа жинхэнэ ёсоор тулалдаж үзээгүй, чадах ч үгүй нь мэдээж байв. Сэм илдээ газраас авч, салхи исгэрүүлэхэд Хорлум бүр ч гомдолтой орилоод, дөрвөн хөллөн мэлхий шиг үсэрсээр агуй руу зугтаав.

Сэм илдээ далайн араас нь ухасхийв. Хоромхон зуурт бүх юм мартагдаж, Хорлумыг алахаас өөр юу ч толгойд нь байхгүй болсон байв. Гэвч урдаас нь хар өмхий нэлхийхэд сая сэхээ авч, Фродо мангасын аманд байгааг санаад эргэж, байдаг хурдаараа гүйв. Гэвч оройтжээ.

Бүлэг 20

Сэмийн сонголт

Фродо хадан дээр түрүүлгээ харан хэвтэж байв. Дээрээс нь нэг ой гутам муухай амьтан бөхийн харна. Тэр Сэмийн хашгирахыг сонссонгүй, гүйн ирж явааг ч анзаарсангүй. Сэм гүйж очтол Фродоо мөрнөөсөө шагайгаа хүртэл аалзны шүлсэнд ороогдсон байх бөгөөд мангас түүнийг урд хөлөөрөө чирэн одов. Фродогийн эльф илд газарт гялалзан хэвтэж байхыг хараад Сэм огтхон ч эргэлзэлгүй түүнийг шүүрэн авангууд тулалдахаар ухасхийв. Амьтны ертөнцөд ийм үзэгдэл үнэхээр сонин харагдах байв. Ердөө хоёрхон хурц соёотой бяцхан амьтан хайрсан хуягтай аварга биет мангас руу дайрч байдаг.

Аалз цуст идээгээ яаран идэх шуналдаа бялуурах шахаж байтал араас нь хашгирахыг сонсоод аажуухан эргэж харав. Тоомшгүй олон жилийн аалзны амьдралдаа тэр ийм их уур хилэн, хорсол заналтай тулгарч байгаагүй юм байна гэдгээ ойлгох хооронд хурц илд нэг хавчуурыг нь тас цавчиж, бүр ч хурц нөгөө илд олон нүдэт бөөрөнхий рүү нь шигдэж, аалз сохров. Өчүүхэн амьтан аварга мангасын хатгуур, хавчуураас бултаж, гэдсэн доогуур нь оров. Түүний дээрээс тунгалаг ногоон гэдэс пэндийж харагдахад өмхий үнэрт нь амьсгал боогдох шахан, эльфийн илдээр тэр гэдэс рүү дүрж орхилоо.

Гэвч Шелоб луунуудтай адил биш байв. Тэрний зөвхөн нүд нь л эмзэг байжээ. Арьс нь зузаан хайрстай, дотор нь чулуужсан ялгадас, дээр нь бас олон давхар хатуурсан ялгадас хурсан байв. Сэм илдээрээ тэр бузар гэдсийг хүүлсэн боловч тэр давхар давхар хуягийг нь нэвгэлсэнгүй. Тэрнийг Берен ч, Турин ч, эльфийн ч, гномын ч илдээр цоолж чадахааргүй байлаа. Гэдэс нь гэмгүй хүүлэгдсэн учир аалз хэнэг ч үгүй зогсч, шархнаас нь хортой шингэн хөөсрөн гарч байв. Аалз хөлнүүдээ алцайж байгаад, өшөөгөө авах гэсэн мэт Сэмийн дээрээс гэдсээрээ дарав. Гэвч Сэм хөл дээрээ зогсч, өөрийнхөө илдийг унагаад, хоёр гараараа эльфийн илдээ гэдэс рүү дүрэв. Аалз түүнийг няц дарахаар гэдсээрээ дарж хэвтэхдээ илдийг улам ч гүн орууллаа. Нэг ч баатар Тернийг тэгж лав дүрж чадахгүй биз ээ. Илд хичнээн гүн орох тусам өмхий гэдэс Сэмийг төчнөөн их хүчээр газарт няхаж байв.

Шелоб олон зуун жил хар хороо үйлдэхдээ ингэж их өвдөж байсан удаагүй тул бүх бие нь салганан чичирч, босон харайгаад, олон хөл дээрээ хол харайв. Сэм Фродогийн толгойн дэргэд өвдөглөн суулаа. Өмхий үнэрт ухаан нь балартаж байв. Тэр Фродогийн нүүрийг дөнгөн данган харж, ухаан алдахгүйг хичээж байлаа. Тэр толгойгоо өндийлгөж, хэдхэн алхмын цаана байгаа мангасыг харав. Олон нүдэт нэг бөмбөлөг нь унтарч, ногоовтор шингэн гоожин, хорт шүлс нь савирч байна. Нөгөө бөмбөлөг нь түүн рүү аймшигтай занал дүүрэн бөлтийж байв. Мангас гэдсэн дээрээ цүлхийн хэвтээд, хөлнүүд нь чичрэн үсрэхэд бэлтгэв.

Сэм түүний нүднээс үхлийг олж харав. Гэнэт тэр алс холоос хэн нэгний дуудахыг сонсч, зүүн гараараа Галадриэлийн бэлгийг тэмтэрч үзэв..

- Галадриэль! – гэж аяархан шивнэхэд эльфүүдийн дуу чихэнд нь хангинаж, Элрондын өргөөнд сонссон хөгжим уянгалвай.

Гилтониэль А Элберет!

Тэгээд дуу орж, үл мэдэх хэлээр:

А Элберет Гилтониэль

О менель палан-дириэль,

Ле наллон си дингурутос!

Атиро нин, Фануилос! – гэж дуудав.

Тэгээд Хэмбриджийн хүү Сэм хөл дээрээ бослоо:

- Хүрээд ир хар бузар аа! Чи эзнийг минь шархдуулсан, одоо чи миний гараас гарахгүй. Бид цаашаа явна, гэхдээ эхлээд чамайг зүйл дуусгана!

Сэмийн няцашгүй их зориг Галадриэлийн гэрлийг асаасан шиг бүрэг харанхуйг нэвтрэн мөнгөлөг гэрэл цацарлаа. Тэр гэрэл Шелобыг аянга мэт ниргэж, шархадсан нүд нь тэсэхийн аргагүй өвдөн, эрүүл нүд нь сохрох шиг болов. Аалзан мангас гэдэргээ харан унаж, олон урт хөлөөрөө гэрлийг хаахыг оролдон татваганаснаа эргэж, хавчууруудаараа хад чулуунаас тэмтчин зуурсаар агуй руугаа санд мэнд мөлхөв. Тэр татваганан чичирч, өмхий ялгадас цувуулан агуй руугаа ороход, Сэм өөр рүү нь тэмтэрсэн нэг хөлийг нь тас цавчив. Тэгээд ухаан алджээ.

Сэм ганцаараа үлдэв. Харанхуй өтгөрөхөд сэргэж, эзэн рүүгээ буцаж мөлхлөө.

- Эзэн минь ээ, эзэн минь – гэж дуудсан ч Фродо дуугарсангүй. Түүнийг чөлөөлөгдсөндөө баярлан ухаангүй гүйж явахад Шелоб ганцхан том харайгаад гүйцэж, хүзүү рүү нь хорт хатгуураа дүрсэн ажээ. Одоо Фродо ухаангүй, хөдөлгөөнгүй тэрийн хэвтэж байлаа.

- Эзэн минь ээ, эзэн минь! – гэж Сэм хичнээн дуудавч нэмэр алга.

Тэр эзнийхээ биеийг ороосон аалзны шүлсийг болгоомжтой таслаад зүрхийг нь чагнаж, уруулыг нь тэмтэрч үзэв. Фродогийн зүрх нь цохилсонгүй, уруул нь хатуурсан байлаа. Гар, хөлийг нь үрж, духыг нь илэв.

- Фродо, ноён Фродо, эзэн минь! Намайг ганцааранг минь бүү орхиоч! Таны Сэм чинь байна, дуугараач! Намайг бүү орхиоч! Сэрээч, Эзэн минь! Сэрээд өгөөч дээ, сэрээд өгөөч!

Тэгээд галзууртлаа уурлан, эзнийгээ тойрон гүйж, агаар исгэрүүлэн хад, чулуу цавчиж гарав. Дараа нь Фродогийн дээрээс тонгойж, хар чулуу дэрлэсэн цонхигор цагаан нүүр рүү нь удаан ширтлээ. Гэнэт Галадриэлийн толинд яг ийм царайтай Фродо хадан хясааны дэргэд унтаж байгаа харагдсаныг саналаа. Тэгэхэд унтаж байна гэж бодсон юм, гэтэл үнэндээ...

- Үхчихэж! Унтаагүй... Үхчихсэн байна - гэж Сэм уулга алдав.

Ингэж хэлэнгүүт хүйтэрсэн цусанд нь хор тарж байгаа юм шиг Фродогийн царай хар ногоон өнгөтэй боллоо. Хар цөхрөл Сэмийг эзэмдэж, тэр нүүрээ газарт наан, юүдэнгээрээ толгойгоо бүтээгээд, уй гашуудаа бие нь хөшин ухаан алдав.

Харанхуйн дунд Сэм ухаан оров. Хичнээн удаан ухаангүй хэвтсэнээ ч мэдсэнгүй. Уул нураагүй, хад чулуу бутраагүй боловч эзэн нь үхчихсэн, өөрөө дэргэд нь хэвтэж байлаа

- Би яах вэ? Одоо юу хийх вэ? Ийм их замыг шал дэмий туулсан гэж үү... - гэж шивнэхэд аян замд гарахын өмнө өөрийнх нь хэлсэн үг гэнэт санагдав. Тэгэхэд яагаад тэгж хэлсэнээ өөрөө мэдээгүй билээ: “Би танд заавал хэрэг болно. Энд, Хоббитанид биш... хэрэв миний юу ярьж байгааг та ойлгож байгаа бол”...

- Би юу хийж чадах вэ? Амьгүй биеийг нь чулуун дээр орхиод гэр рүүгээ зугтаах уу? Цаашаа явах уу?

- Цаашаа? – гэж давтан асууснаа айх шиг болов:

- Цаашаа гэдэг чинь юу гэсэн үг вэ? Би ч яахав, цааш явдаг л байж, эзнийг орхих юм уу?

Тэгээд уйлж, Фродогийн биеийг цэгцэлж, гарыг нь цээжин дээр нь зөрүүлж, цуваар нь хучаад нэг талд нь өөрийнхөө илдийг, нөгөө талд нь Фарамирын таягийг тавив.

- Хэрэв би цаашаа явах хэрэгтэй юм бол таны илдийг авъя даа, өршөөгөөрэй. Мифриль хуяг чинь танд үлдэг, ноён Бильбогийн бэлэг шүү дээ. Бас энэ, таны гэрэлт аяга. Та надад хадгалуулсан, дахиад надад маш их хэрэг болно. Хатан хаан ойлгох байх. Харин та ойлгож байна уу, эзэн минь? Нэгэнт би ганцаараа цааш явахаас хойш.

Гэвч явах зүрх хүрсэнгүй, Фродогийн хүйтэн гарыг нь барин суусаар, цаг явсаар байлаа. Өшөөг нь авахын тулд ганцаараа цааш явна, ямар ч саадыг давж, Дундад газрыг нэлд нь хэрэн бэдэрнэ, Хорлумыг алтлаа идэж уухгүй. Гэвч үүний төлөө тэр эзнээ дагаж алсын замд гараагүй, үүний төлөө түүнийг орхих ч хэрэггүй. Хорлумыг аллаа гээд эзэн босоод ирэх юм биш. Тэгснээс дэргэд нь хэвтээд үхсэн нь дээр.

- Тэгээд яах вэ? Би юу хийх ёстой вэ?

Хариулт нь энгийн бөгөөд хатуу байв. Хэрэг болно гэж амласан бол хэрэг бол, түүний өмнөөс хийх ёстойг нь хий. Чи ингэх ёстой.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? Би ганцаараа Галт уул руу явах юм уу? Би бөгжийг нь авч явах хэрэг үү? Зөвлөл надад биш, түүнд даалгасан биш үү?.

Хариулт нь бас л түргэн бөгөөд энгийн байв:

- “Зөвлөл бөгжийг түүнд даалгаад, тусал гэж биднийг өгсөн. Одоо би ганцаараа үлдсэн тул би л даалгаврыг гүйцэтгэнэ”.

Сэм гүнээ санаа алдав.

- Ийм л байна даа, бодоод байх юм алга!

Тэр Фродогийн дээрээс тонгойж, захных нь товчийг тайлаад, амьгүй толгойг нь өргөн духан дээр нь үнсч, дараа нь бөгжний гинжийг тайлж авлаа. Тэгээд толгойг нь чулуун дээр дэрлүүлэхэд хөшсөн царай нь өчүүхэн ч өөрчлөгдсөнгүй. Тэгэхэд л “Фродо үхсэн байна, одоо даалгавар түүнд ямар ч хамаагүй болжээ” гэж ойлгов.

- Баяртай, хайрт эзэн минь! Муу Сэмийгээ өршөөгөөрэй. Заавал энд эргэж ирнэ, зөвхөн чиний үйлсийг гүйцээх хэрэгтэй байна. Тэгээд дахиж салахгүй. Одоохондоо тайван нойрсч бай! Дайснууд энд ирэхгүй. Хатан хаан намайг сонсч, эргэж ирээд чамайг олох замыг минь засах болтугай. Баяртай!

Тэгээд тонгойж, бөгжийг зүүхэд хүзүүнээс нь доош хүндээр чангаалаа. Гэвч шинэ хүч орсон юм уу, ачаанд дассан юм уу тэр дорхноо өндийн босоод, явж чадна, ачааг даана гэдгээ мэдрэв. Аяганыхаа гэрэлд Фродогийн царай руу дахин нэг харав. Нүүрнээс нь үхлийн сүүдэр арилж, тайван, эльфийнх шиг гоо сайхан харагдав.

Гарцаас хавцал хүртэл зуун мод хүрэхгүй зайтай байв. Харанхуй ч гэсэн жим харагдаж, удалгүй элэгдсэн хавтгай гишгүүртэй шат болж хувирлаа. Чанх дээр нь харуулын хар цамхаг улаан нүдээ улалзуулан сүндэрлэнэ. Шат дуусч, хавцал эхлэв.

- Шийдсэн хүнийг эргүүлж болдоггүй – гэж өөртөө хэлэвч яагаад ч юм зүрх сэтгэл нь эргэж хоргодоод байлаа.

- Буруу шийдсэн юм болов уу? Яах ёстой байсан юм бол? – хэмээн бувтнав.

Хавцалд руу орж, Дайсны хөндий рүү уруудсан зам дээр гарахын өмнө эргэж харлаа. Ичээний нүх онгойн харлаж, тэндээс баруун тийш гучин мод зайд Фродо хэвтсээр үлдэв. Тэнд ямар нэг гэрэл сүүмэлзэх шиг болов. Нулимс тэгж харагдав уу?

- Надад ганцхан л хүсэл байна. Буцаж түүн дээр очих!

Хүчлэн байж хоёр гурав алхав. Хөл нь захирагдахгүй байлаа. Одоо хэдхэн алхаад л доошоо буух болно. Гэтэл гэнэт хашгиралдан шуугилдах сонсогдов. Тэр дороо нам зогслоо. Өмнө нь ч, ард нь ч орхууд түчигнэлдэж, зэрлэгээр хараах дуулдана. Эргэж харвал хясааны бэлээр гэрэл гялалзаж байлаа. Араас хөөж байна. Цамхгийн цонхоор улаан гэрэл улалзан дохиж байна. Тэр хоёр галын хооронд хавчигдах нь энэ. Урд талын гэрэл улам ойртож, төмөр хангинана. Минутын дараа тэд хүрээд ирнэ. Хаашаа зайлах вэ? Бөгжийг яаж аврах вэ? Тэр удаан тээнэгэлзсэнгүй, бөгжийг авч атгалаа. Түрүүчийн орх яг урдаас нь гараад ирмэгц бөгжийг хуруундаа углав.

Бүх юм өөр болж, нэг минут бүтэн цаг шиг уртсав. Сонсгол нь сонор болж, хараа бүүдгэрлээ. Зүүн гарыг нь доош чангааж байгаа бөгж алтан өнгөөр гялалзав. Тэр өөрийгөө үзэгдэхгүй байгааг мэдэрсэнгүй, харин ч тал талаас нь харж, бүхнийг харагч нүд түүнийг сандчин эрж байгаа нь мэдрэгдлээ. Чулуу шажигнах, Моргулийн хөндийд ус урсах, Шелоб ичээндээ пүл пүл хийлгэн ёолох, газар доор хоригдлуудын ёолох, орхуудын орилолдох чимээ бүгд нэгэн

зэрэг сонсогдолоо. Орхууд хажуугаар нь түчигнэлдэн гүйж, өөрөө хясааны хана налан зогсч байв.

Хоёр талаас гүйлдэн ирсэн орхууд уулзаж улам ихээр шуугилдав. Сэм тэдний үгийг тод сонсч, яриаг нь төвөггүй ойлгож байлаа. Бөгжний хүч түүнийг давсан газраас холгүй байгаа учраас хэдэн зуу дахин нэмэгдсэн бололтой, гэвч Сэм зориг мохсонгүй, зөвхөн хаана нуугдаж хүлээхээ бодож, чих тавин чагнаж байв. Орхууд яг хаана ярилцаж байгаа нь мэдэгдэхгүй боловч яг чихэн дээр нь ярьж байлаа.

- Хараач? Горбаг! Чи энд юугаа хийж яваа юм бэ? Байлдаж залхаа юу?

- Тушаал аа, шүлстэй хоншоор оо! Шаграт, чи яах гэж энд бөгсөө чирж ирээ вэ? Байлдахыг хүсээ юу?

- Энд би тушаадаг юм, амаа хамхи чи. Юу олоо вэ?

- Баасыг чинь.

- Гей! Гой! Эге-гей! – хэмээн орилолдох дуу энэ яриаг таслав. Доор байсан орхууд ямар нэг юм олжээ. Бусад нь ч гүйж ирлээ.

- Го-го-го! Зам дээр нэг юм хэвтэж байна. Тагнуул, тагнуул!

Сөөнгө бүрээнүүд уралдан улив.

Сэм гэнэт сэхээ авч, айхаа ч болив. Эзнийг нь олчихож. Одоо түүнийг яах бол? Цус хөрмөөр хачин яриа сонсч байсан учир тэр босон харайв. Тэгэхгүй шүү! Яавал ч яаг, амьд ч бай, үхсэн ч бай, эзнийхээ л дэргэд байя!

Тэр шатаар гүйхээрээ бууж, Фродогийн байсан газар руу хурдаллаа.

“Хэдүүл байгаа бол? Цамхгаас дөчөөд орх гарсан, доор бас тэр хавьцаа байгаа, олон ч байж мэднэ. Би хэдийг нь унагаж дийлэх бол? Хөх галтай илдийг минь тэд үзэх учир эрт, орой ямар ч гэсэн намайг унагаана. Нэгэн цагт “Баатар Сэммиум даваан дээр эзнээ хамгаалан амь үрэгдсэн тухай” дуу зохиогдвол сайн л байна. Юуны чинь дуу! Бөгж дайсны гарт орвол дуу зохиогдохгүй. Тэр яахав дээ, би ноён Фродогийн дэргэд байх ёстой. Тэд:

Элронд, зөвлөлийн мэргэд намайг ойлгоно биз, өөрсдөө буруу тооцоолсон байна. Би хадгалагч болж чадахгүй, би Фродотой л хамт байх ёстой”.

Гэвч хичнээн гүйгээд газар хороосонгүй, хөл нь улам хүндэрч байлаа. “Аа, тэр байна, шавааралдаад л, зарим нь эргэн тойронд газар шиншилж байна. Ямар хол байна аа!”

- За хурдлаарай, Сэм! Алдчихвал юу болох вэ? - хэмээн өөрийгөө шавдуулаад илдээ тэмтэрч үзэв. Илдээ сугалаад...

Орхууд зэрлэгээр орилолдов:

- Нээг - хооёр - гууррваа! Оп! Оп!

- Алхаад марш, эгнээ тэгш! Доод хаалга руу шууд!

Орхууд бөөнөөрөө хөдөлж, дөрөв нь Фродог дамжлан дунд нь оржээ.

- Го-гой!

Тэд Фродог аваад явчихлаа, одоо гүйцэхээсээ өнгөрлөө, гэвч Сэм гүйсээр л байв. Орхууд нүхэн цооног руу орох үед Сэм амжин гүйцэж, илдээ сугалсан боловч сүүлчийн орх нүх рүү орчихов. Сэм зогсч амьсгаагаа дараад, хөлс, нулимсаа шудран арчингуут араас нь өмхий нүх рүү шургав.

Нүх тийм ч харанхуй биш байлаа. Улам их ядарч байсан ч хурдаа нэмэв. Бамбаруудын гэрэл ойрхон ёлтолзох авч огт гүйцэхгүй байв. Сэм тэдний зэвтэй төмөр үрэлдэн хяхтнах мэт яриаг сайн сонсч байв. Хамгийн сүүлд яваа хоёр толгойлогчийн яриа бүр ч тод дуулдав.

- Цаад тэнэгүүдээ дуугүй болгооч, Шаграт. Шелоб одоо гараад ирнэ дээ!

- Бүү өмхийр, Горбаг! Чиний адгууснууд ч дутуугүй орилж байна даг! Орилцгоож л байг. Шелоб ичээнээсээ гарахгүй, Өмхий нүхнийхээ ам хүртэл хичнээн юм савируулсныг хараагүй юу? Хадаасан дээр хэвтчихсэн юм уу яасан юм. Харин аз таарлаа. Лугбурзийнхан сэтгэлд хангалуун байх биз.

- Хуцав аа. Лугбурзийнхан юундаа сэтгэл ханах юм бэ! Нэг муу эльфийн зулбадас. Онц аюултай тагнуул уу, ямар?

- Мэдэхгүй, нүдээрээ харах хэрэгтэй.

Бамбарууд хаа нэг тийш алга болов. Сэм гүйж иртэл орхууд мухар нүхээр орсон байлаа. Нүхний амыг тагласан том хадыг тэд зайлуулж ороод, буцаагаад хаачихжээ. Цаад талаас нь тэдний дуу соногдож байв. Сэм хадан хаалтыг хөдөлгөж чадсангүй. Толгойлогчид үлдсэн бололтой, хоорондоо ярилцах нь дуулдлаа.

- Дээр байгаа дээдэс нэг л хачин байна. Тэр далавчит сүгнүүд бүр даварч байна гээч. Тэд ч надад хэрэггүй, энэ өмхий аалз ч хэрэггүй. Даан ч хаачих вэ дээ, дайн болж байна, дараа нь л юу юм гэхээс...- гэж Горбагийн дуу гарав.

- Дайн дажгүй болж байна гэцгээх юм.

- Тэд ч тэгж л хэлнэ л дээ, харж байж л мэдье. Урукхай биднээр онгорхой цоорхой бүхнээ бөглөж л байг! Чи тушаал хэзээ авсан бэ?

- Цагийн өмнө. Тэгээд л бид уулзчихлаа шүү дээ. “Далавчтанууд түгшүүртэй байна. Шатан дээрх тагнуулчдаас сэрэмжил. Хамгаалалтыг хоёр дахин нэмэгдүүл. Шатан дээр харуул гарга” гэж тушаасан.

- Дайснууд шатан дээр гараад ирсэн юм биз дээ? Ингэхэд чи хаана байсан юм бэ? Онцгой даалгавар хүлээж байсан юм уу? Дээд хавцал, гарц хоёрыг хэн чиний өмнөөс хамгаалах ёстой юм бэ?

- Амаа хамхи! Бас нэг захирагч гараад ирлээ. Бид бүхэл шөнөжин нүдээ аниагүй. Энд ч хачин юм болсон доо.

- Ямар хачин юм болсон гэж?

- Хачиан хачин. Гэрэл гялалзаад л, хашгиралдаад л. Шелоб ч зүгээр байгаагүй. Тэр энд Нойтонтой хамт байхыг миний залуус харсан байна лээ.

- Бас юун нойтон бэ?

- Чи тэрнийг харсан ч болоосой. Агийсан хар бөөсний хоол. Аалз шиг ч юм уу, үхсэн мэлхий шиг. Тэр энд урьд нь ч ирж байсан. Гэхдээ бүр Лугбурзаас ирсэн, тэрэнд саад бүү хий гэж бидэнд тушаасан юм. Дараа нь нэг хоёр ирэхэд нь бид хараагүй юм шиг л өнгөрөөсөн. Тэр Шелобын аргыг яаж олсон юм бүү мэд. Бодвол яс арьс хоёроос юу нь сорох вэ гэж голоо биз. Тэрнээс биш эмгэн дээрхийн тушаалыг нулимж л орхино. Мэдээж, Нойтон эмгэнд ямар нэг амьд шүүс дагуулж ирсэн байж таарна.

- Чи наад хоёр ёлтгороо нээгээч! Нэг л юм болохоо байчихлаа гэж би чамд хэлээд байна шүү дээ. Эмгэний шүлсэн торыг хүүлж хаячихаад гараад явчихсан байна шүү дээ!

- Гэхдээ тэрнээс зугтааж чадаагүй, тийм биз?

- Хэн чадаагүй гэж? Энэ муу өөдөс үү? Хэрэв тэр ганцаараа байсан бол аль хэдийн дээд давхрын агуулахын тавиур дээр хэвтэж байх байсан юм. Чиний аз таарлаа л гэж бод. Тэр ганцаараа байгаагүй.

- Хэн тэрнийг сулласан байж таарах вэ аа, Шаграт? Нөгөө торыг тасчиж хаясан этгээд л байхгүй юу. Ойлгохгүй байна уу? Хэн Шелобыг аргалсан бэ? Бас л тэр. Тэр одоо хаа байна, Шаграт?

Шаграт дуугарсангүй.

- Чи наад бөндгөрөө ажиллуул, манайхан алга байна, энэ завшааныг ашигла. Энэ тоглоом биш шүү! Хэн ч, хэзээ ч Шелоб руу зүүгээр хатгаж байгаагүй, чи надаас дутуугүй мэднэ. Эмгэнийг өрөвдөх хэрэггүй, хохь нь тэр. Гэвч бодоод үз. Чиний хажуугаар аймшигтай дайсан хэсүүчилж явна. Хэзээ ч ийм юм болж байгаагүй. Ерөнхийдөө болохоо байчихаж.

- Ямар гээч дайсан байж таарах вэ?

- Бодвоос тэр бол аварга баатар. Эрхэм найз Шаграт минь, эльфийн илдтэй эльф баатар. Бас саран сүх ч байгаа. Тэр чиний дэргэдүүр зугаалж байдаг, чи амаараа ялаа үмхэж байдаг! Ярих ч юм алга! – гээд Горбаг нулимав. Сэм өөрийг нь ямраар төсөөлж байгааг сонсоод мушилзав.

- Чи дандаа л муу ёрын юм ярьж байдаг даа. Би энд тэндгүй харуул тавьсан. Хоёр хоёроор нь. Олсныгоо сайн харж аваад юу хийхээ бодно.

- Тэр муу өөдөс рүү шууд нулимсан нь дээр. Тэр зүгээр л дагаж явсан. Хурц илдтэй аварга баатар тэрнийг тээршээгээд зөнд нь хаячихсан. Эльфүүд тийм л улс.

- Харж байж л больё. За, үг олдлоо. Барьсан этгээдийн учрыг олъё.

- Чи тэрнийг яах санаатай байна? Миний залуус тэрнийг олсон гэдгийг битгий мартаарай. Хэрэв гэдэс дотрыг нь гаргахад хүрвэл бид эхэлнэ.

- Больж үз, надад тушаал өгсөн. Тушаалыг хэн ч зөрчих эрхгүй. Зөрчвөл чи бид хоёрын толгой түрүүлж өнхөрнө. Баригдсан ямар ч зөрчигчийг цамхагт хорь. Чармаа нүцгэл. Хувцас, зэвсэг, захиа, бөгж, ямар ч жижиг зүйлс байсан бүгдийг нь бүрэн жагсааж бич. Жагсаалтыг зөвхөн Лугбурзэд яаралтай хүргэ. Баригдсан хэнийг ч гэсэн хуруугаараа ч хөндөж болохгүй. Зөрчсөн этгээдийг цаазална гэдгийг анхааруул. Эзэн өөрөө юм уу элч нь ирэх хүртэл нүдний цөцгий мэт хамгаалж бай – гэж тушаасан даа. Тушаал ойлгомжтой байна, би нэг бүрчлэн биелүүлэх л үүрэгтэй.

- Тэр ч яамай байна аа - хэмээн Горбаг пар пар хөхөрч:

- Хүүрийг хамгаалж яах юм бэ? Лугбурз хүүрээр дугаа юу? Оройн хоолонд чанаад л гүйцэх биш үү?.

- Чалчаа амьтан! Хэл нь урт, ухаан нь богино. Өөрөөсөө ухаантай хүний үгийг авбал барав! Өөрөө Шелобын оройн хоол болчихов, мэдээтэй байгаарай. Хүүр гэнэ шүү! Эмгэний энэрэнгүй занг чи мэдэхгүй байна даа! Хэрэв тэр олзоо өлгийдсөн бол махыг нь амталж байгаа юм, тэр хүүр иддэггүй, үхдлийн цус ч уудаггүй. Тэр өөдөс амьд байгаа!

Сэм унах шахан найгаж, хаднаас зуурав. Хар ичээ орвонгоороо хөрвөх шиг санагдав. Арай ч ухаан алдчихсангүй, өөрийнхөө дотоод дуу хоолойг сонслоо: “Чи ч тэнэгийн тэнэг юм даа, тэр үхээгүй. Зүрх чинь мэдээд байсан, харин толгой чинь цэцэрлэгийн толгой, тэрнийгээ зүгээр далдхан шиг хийчих. Чи найдвар алдсан чинь үнэн, гэвч Сэм, гэвч бүр эхнээсээ л юунд ч найдаагүй өдий хүрсэн биз дээ. Одоо тэгээд яах гэж байна?”

Гэвч Сэм одоохондоо яахаа ч мэдэхгүй, хүйтэн хад түшээд орхуудын ой гутам яриаг л сонсч байлаа.

- Ээ хөөрхий зулбадас минь! Эмгэн чинь олон янзын хорыг өөр өөр зорилгоор хэрэглэдэг юм шүү дээ. Тэр ан хийхээрээ хүзүү рүү нь хатгаад, суганаас нь жаахан зөөлөн мах боож аваад, дараа нь тансагладаг юм. Хөгшин Уфтхакийг санаж байна уу? Тэг нэг өдөр алга болчихсон. Хоёр хоног бараа сураггүй, гурав дахь өдөр нь бид явж байтал нэг буланд өлгөөтэй, амьдаараа, бидэн рүү бүлтийтлээ харж байсан шүү. Бид ч элгээ хөштөл хөхөрцгөөсөн. Эмгэн тэрнийг өлгөчихөөд мартчихсан ч юм уу, бүү мэд. Бид тэр чигт нь орхичихсон, эмгэнтэй муудалцаад хэрэггүй. Энэ бөөсний хоол цагийн дараа л сэргэнэ.

- Тэгвэл тэрнийг оролдож болохгүй юм бол зүгээр л яриад өгчихье. Лугбурзийн ордонд тэр орж үзээгүй нь мэдээж, жаахан бэлтгэхгүй бол дасаагүй болоод айх байх. Зугаа зугаанаасаа дугахгүй. Явья!

- Би чамд хэлээд байна шүү дээ, зугаалж болохгүй гэж. Тэрний ой ухаан муудчихвал чи бид хоёр хүүр болно.

- За битгий айлгаад бай. Би чиний оронд байсан бол нөгөөдөх баатрыг нь барьж аваад Лугбурзт ч илтгэхгүй байсан. Тэнд муурыг нь алдаад зулзагыг нь барихыг мэдээгүй юм шиг өнгөрдөг шүү дээ.

Орхууд явж одов. Сэм сэргээд галзууртлаа уурлав:

- Би мэдээд байсан юм аа! Одоо эзэн минь энэ бузар новшнуудын гарт байна. Ямар ч нөхцөлд, хэзээ ч эзнээ орхихгүй байхад л болох байсан шүү дээ! Цэцэрхээд байх юм бахгүй! Одоо арьс магнаасаа мултарч байгаад ч хамаагүй эзнээ олох хэрэгтэй!

Тэр илдээ сугалаад бариулаар нь хадан ханыг тогштол хана хөндий дүнгэнэж, илд тодоос тод гэрэлтэв. Тэр гэрэлд хартал хана биш, өөрөөс нь бараг хоёр дахин өндөр хадан хаалга байлаа. Хаалга, тааз хоёрын хооронд нарийхан завсар байх бөгөөд цаад талаасаа түгжээтэй болох нь илт. Шелобын талаас түгжигдсэн байлаа. Сэм дээш үсэрч хаалганы тотгоноос барьж аваад, завсраар нь шургаж орон, буунгуутаа гэрэл цацарсан илдээ барин байдгаараа хурдлав. Эзэн нь амьд байгааг мэдээд тэр ядарснаа ор тас мартжээ. Өмнө нь юу ч харагдсангүй, хонгил олон удаа муруйж тахирласан байлаа. Тэр орхуудыг гүйцэж түрүүлсэн бололтой, хажууханд нь хоёр орхын ярилцах дуулдав.

- Хэлснээрээ л хийнэ, хамгийн дээд талын нууц өрөөнд түгжинэ – гэж Шаграт ууртай хэлэв.

- Яах гэж? Доод давхарт чамд найдвартай өрөө байхгүй юм уу?

- Та нараас хол байлгана гэж хэлсэн шүү дээ. Ойлгоогүй юм уу? Тэрэнд гар хүрч болохгүй, би өөрийнхөө залууст ч гэсэн бүгдэд нь итгэдэггүй, чиний залууст бол бүр эртнээс. Чамд ч гэсэн нэг их итгээд байдаггүй. Би хариуцлага хүлээж байгаа болохоор чамайг тэрэнд ойртуулахгүй. Хамгийн дээд давхарт, тэнд хэн ч ойртохгүй.

- Хэн ч ойртохгүй гэв үү? Дэргэд чинь байгаа эльфийн баатрыг бүр мартчихсан уу! – гэж Сэм хашгираад эргэлтээс гүйн гарч ирсэн боловч бөгж дэндүү сонор байсан бололтой, хоёр орх их хол харагдав. Горбаг, Шаграт хоёр доод давхрын хаалгаар орж явлаа.

Сэм хашгирч, гэрэлт илдээрээ далласан боловч түүний дуу орхуудын шуугианд дарагдаж, хэн ч түүнийг анзаарсангүй.

Нүсэр хаалга хяхтнан хаагдав. Сэм хар хурдаараа гүйж яваад хаалга мөргөж унан ухаан алдав. Тэр ганцаараа гадна талд, хав харанхуйд үлдлээ. Фродо амьдаараа Дайсны гарт оржээ.

ГУТГААР ДЭВТЭР

Бүлэг 1

Минас Тирит

Пин Гэндальфын цувны захаар шагайж харав. Тэр унтаад сэрэв үү, эсвэл Аянга дүүлэн давхихад сэрүүн зүүдлэн унтаад өгсөн чигээрээ байна уу гэдгээ ойлгосонгүй. Нөгөө л харанхуй хажуугаар түнэрэн өнгөрч, чихэнд салхи исгэрнэ. Зөвхөн жирвэлзэн солигдох одод харагдаж, тэнгэрийн баруун тал нэлэнхүйдээ харанхуйлжээ. Тэр одоо хаана яваа, хичнээн газар явснаа нойрмоглон санах гэж оролдсон боловч ой ухаан нь орон гаран будангуйрч байв.

Эхлээд тэр гурав харвасан сум мэт хурдлан давхиж, үүрийн гэгээнд шилтгээнүүдийн титэм алтран гялалзсан нэгэн нам гүм хотод орж ирсэн, бас уулан дээр нэгэн эзэнгүй ордон байсныг санав. Тэднийг дөнгөж нуугдав уу, үгүй юу далавчтай сүүдэр дахин нисэн ирж, хүмүүс айсандаа яаж ч чадахгүй байсан. Гэндальф түүнтэй ямар нэг юм эелдэг зөөлнөөр ярьж байсан, өөрөө хаа нэгтээ буланд унтаж байсан, хүмүүс нааш цааш холхиж, Гэндальф тэдэнд тушаал өгч байсан. Дараа нь тэр гурав дахиад л давхисан, шөнийн харанхуй дундуур давхиад л байсан. Хоёр дахь шөнө, биш ээ гурав дахь шөнө нь тэр Чулуу руу харсан. Тэр аймшгийг санахад өөрөө нойроос сэрж, чичирч байсан, шуурга янз янзын дуугаар заналтайяа хашгирч байсан санагдана. Тэнгэр хар сүүдрийн цаанаас шаргал туяа татуулж, Пиний бие агзасхийж, улам жижигрэн эвхрэх зуураа энэ Гэндальф намайг хааш нь, ямар хязгаар руу авч яваа юм бол доо – гэж гайхав. Тэр нүдээ арчин харвал сар дорнын сүүдрээс бараг бүтнээрээ гараад иржээ. Тэгэхлээр шөнө дөнгөж эхэлж байгаа юм байна, харанхуй тэнгэрийн доогуур дахиад зөндөө давхих юм байна гэж ойлгов.

Тэр жаахан хөдлөөд ярьж эхлэв:

- Бид хаана явна аа, Гэндальф?

- Гондорын нутагт орж байна, одоохондоо Анориэнд явж байна.

Хэсэг дуугүй давхисны дараа Пин Гэндальфын ханцуйнаас чангааж:

- Хараач! Гал, час улаан гал! Тэнд юу байгаа юм бэ? Луу юу? Дахиад нэг гал! – гэж хашгирав.

Хариу хэлэхийн оронд Гэндальф мориндоо хандаж:

- Яарцгаая, Аянга минь! Сүүлчийн хугацаа ойрхон байна. Чи харж байна уу, Гондор дуудлагын дохиогоо асаалаа, аюулын дохио. Дайн эхэллээ. Тээр тэнд Амон-Диний гал аслаа, Эйленахийн гал ч аслаа, цаашаа Нардол, Эрелас, Мин-Риммон, Кэленхадын гал аслаа, за тэр Ристанийн хил дээр Галифириэний гал ч аслаа!

Аянга давхиж байснаа шогшиж, тэгснээ алхалж, толгойгоо өргөөд чангаар янцгаав. Хариу янцгаах сонсдож, туурайн төвөргөөн сонсогдов. Харанхуйгаас гурван морьтон гараад ирснээ баруун зүг сарны туяанд уусах мэт нисэн алга боллоо. Аянга биеэ хөвчлөн дүүлэхэд дахиад л шөнийн салхи чихэнд исгэрэв.

Гэндальф гондорчуудын заншлын тухай, хаан нь хоёр талын уулан дээр дохионы галын цамхаг барьж, цамхагт байнгын харуул суулган, мэдээ хүргэх сэлгээ морьд бэлэн байлгахыг тушаасан тухай ярьж байгааг Пин зүүрмэглэх зуураа сонсов.

- Умард нутагт дохионы гал асаалгүй их удсан даа, Гондорт дохионы гал асаах шаардлага гарч байгаагүй, долоон Чулуу л хангалттай байсан – гэхэд Пиний бие агзасхийн цочив.

- Унт унт, битгий ай!- гэж түүнийг Гэндальф тайвшруулаад - Фродо л Мордор руу явж байгаа болохоос, чи биш, чи Минас-Тирит рүү явж байна, тэр бол найдвартай цайз. Түүнээс найдвартай нь хаана ч үгүй. Хэрэв Гондор тэсч чадахгүй бол, хэрэв Дайсан бөгжийг эзэмдвэл Хоббитанд нуугдах газар олдохгүй.

- Мөн ч сайхан тайвшруулж байх шив дээ - гэж Пин нойрмоглон хэлэв. Гэвч унтаж байхдаа тэр үүлэн дээгүүр нисэн байгаа сарны гэрэлд гийгүүлэгдсэн цагаан оргилуудыг харж байлаа. Тэгээд - Фродо хаана яваа бол, магадгүй, аль хэдийн Мордорт оччихсон болов уу, эсвэл амь үрэгдсэн болов уу гэж бодов.

Яг энэ үед Фродо ч бас үүр хаяарахын өмнөх тэр сарыг тэртээ алсаас харж байгааг тэр яаж мэдэх билээ.

Хүмүүсийн дуу Пинийг сэрээв. Дахиад нэг хоног өнгөрчээ. Өдөр гэж байхгүй, зөвхөн шөнө. Харанхуй шингэрч, хүйтэн манан газарт буужээ. Аянгын хөлстэй бие гялалзаж харагдавч түүний бардам байдалд ядарсны шинж огт үгүй. Эргэн тойронд өсгийгөө хүрсэн урт цувтай өндөр өндөр хүмүүс зогсч, тэдний цаана хагас нурсан хана харагдах бөгөөд түүнийг яаруу давчуу сэргээн босгож байгаа нь илт, дөнгөж үүр хаяарч байхад энд тэндгүй алхны тогшилт, хүрзний чимээ, тэрэгний дугуй чихрах сонсогдоно. Булингартсан манан дунд бамбар дүрэлзэж, дэнлүүнүүд гэрэлтэнэ. Гэндальф тэднийг зогсоосон хүмүүстэй ярилцаж байх бөгөөд Пин чагнаад, өөрийнх нь тухай ярьж байгааг ойлгов.

- Үгүй дээ, чи хамаагүй Митрандир минь, - гэж тэдний ахлагч хэлээд чамайг бид мэднэ. Чиний өмнө Долоон хаалга нээлттэй гэсэн үг байдаг шүү дээ. Дураараа явж үз. Харин энэ дагуул чинь хэн юм бэ? Гном юм уу? Юу гэх юм бэ дээ, манайд одоо харийнхан хэрэг алга, бидний мэддэг, бидний итгэдэг ард түмнүүдээс хүчирхэг тусламж ирнэ гэж үү дээ?

- Би энэнийг Денэторын хаан ширээний өмнө хариуцна. Жижигхэн биеэр нь түүнийг бүү үнэл. Хэрэв мэдэхийг хүсч байвал Ингольд минь, тэр чамаас хоёр дахин намхан боловч чамаас хамаагүй олон тулалдаан, аюулыг давж ирсэн юм. Би түүнтэй Изенгардаас хамт ирж байна, тэнд юу болсныг та нар удахгүй сонсоно оо. Тэр их ядарсан тэгээд л би сэрээхгүй байгаа юм. Нэрийг нь Перегрин гэдэг юм, энэ эрийн эр зориг та нарын хэнийхээс ч дутахгүй.

- Энэ эрийн гэнэ ээ? – хэмээн Ингольд гайхахад бусад нь инээлдэв.

- Юуны чинь эр! – гэж бүрэн сэрсэн Пин дуу алдаж – Мөн ярив аа, эр хүн гэнэ шүү! Би ямар ч эр хүн биш, харин хоббит байна, тийм ч эр зоригтон биш, заримдаа ухаан алдталаа айж л байсан. Гэндальф та нарын толгойг эргүүлж байна!

- Ийм үгийг эр зоригтон л хэлдэг юм даа - гэж Ингольд бодлогошронгуй өгүүлээд – Тэр хоббит гэдэг чинь ямар хүмүүс юм бэ?

- Хоббит гэдэг бол намхан гэсэн үг – гэснээ Гэндальф хүмүүсийн гайхсан царайг хараад - Үгүй ээ үгүй, намхан гэж энэнийг хэлж байгаа юм биш, тэднийг бүгдийг нь тэгж нэрлэдэг юм, энэ бол тэдний нэг нь.

- Би Гэндальф биш ч гэсэн түүний дагуул нь байна. Танай хотын Боромир ч бидэнтэй хамт явсан, тэр намайг умардын цасан дундаас аварсан, тэр намайг хамгаалж үй олон дайсантай тулалдаж байгаад дайсны суманд амиа алдсан.

- Дуугүй бай! – гэж Гэндальф түүний яриаг таслаад – Энэ гашуудалт мэдээг эхлээд түүний аав нь сонсох ёстой.

- Гашуудалт мэдээг урьдаас таамагласан. Учир нь дөнгөж саяхан ер бусын тугнууд харагдсан. Явцгаа, яарцгаа! Минас-Тиритийн эзэн хааны хүүгийн гавьяаны гэрчийг саатуулж болохгүй, хэн ч бай...

- Хоббит ч бай - гэж Пин түүний үгийг гүйцээгээд – Миний гэрчлэх ч гэж юу байхав, би зүгээр л Боромирын баатарлаг гавьяаны тухай танай хаанд ярьж өгч чадна, би түүнд их өртэй.

- Тавтай морилогтун! – гэж Ингольд хэлэхэд хүмүүс Аянгад зай тавьж өгөв. Хананд нарийхан гарц байх ажээ.

- Денэторт болон манайханд бүгдэд нь мэргэн зөвлөгөө өгөөрэй Митрандир! Чамайг зөвлөгч биш, муу мэдээ авчрагч гэж ярьцгаадаг, чи дандаа гунигтай, аймшигтай мэдээ авчирдаг – хэмээн тэдний араас хашгирав.

- Яагаад гэвэл би гай зовлонд унасан газарт миний тусламж хэрэгтэй болсон цагт л ирдэг юм. Би та нарт ингэж зөвлөмөөр байна: Пеленнорын ханыг сэргээх оройтсон. Харанхуй шуурга одоохон нөмөрнө, зөвхөн өөрсдийнхөө тэсвэр тэвчээрт найдацгаа, тэсээд гарвал та нарт өөр найдвар ч төрнө. Би дандаа муу мэдээ авчирдаггүй. Хүрзээ тавиад, илдээ хурцалцгаа!

- Бид орой гэхэд дуусна аа. Хэрмийг бүхэлд нь сэргээн барьсан, зөвхөн энэ хэсэг л үлдээд байгаа юм. Дайсан Ристанийн талаас ирэхгүй гэж бид бодож байгаа юм. Ингэхэд ристанчууд яах бол? Бидний дуудлагаар давхиад ирэх болов уу? Юу гэж бодож байна? – гэж Ингольд хашгирав.

- Давхиад ирнэ ээ, жаахан хүлээ. Одоогоор тэд та нарын ар нурууг хамгаалж байна. Дайсан хаанаас ч, аль ч талаас, өдөр ч, шөнө ч гараад ирнэ гэж мэд! Гэндальф муу мэдээч биш боловч одоо бут ниргэгдсэн Ристаниас дайсны асар их хүч та нарыг нөмрөн орж ирнэ. Өөр юу ч болоо билээ, яаж мэдэхэв. Баяртай, дээд зэргээр сэрэмжтэй байгаарай!

Тэгээд Гэндальф Раммас-Экорын хөндий рүү оров. Дайсан Итилийг эзлэхэд барьсан алсын

бэхлэлтээ Гондорчууд ингэж нэрлэжээ. Бэхлэлт Андуин мөрний баруун эрэг дэх Пеленнорийн үржил шимт хөндийн эргэн тойронд умард уулаас өмнөд уулс руу арав гаруй лиг үргэлжилжээ. Хэрэмнээс Их хаалга хүртэл ердөө дөрвөн лиг зайтай байв. Минас-Тирит энд эрэг орчмын нам дор газраас хүчирхэг хэрмээрээ зааглагдсан бөгөөд харуулын хоёр цамхагт Осгилиатын гарам болон гүүрнээс ханануудын хоорондуур гарсан өргөн зам хүрч байв. Зүүн өмнө талд энэ хэрэм Эмин-Арнен буюу хааны даланг дайран хот хүртэл нэг лиг зайтай байлаа. Хотын эргэн тойронд өтгөн ургасан тариалангийн талбай, жимсний цэцэрлэг, эдлэн газрууд, Андуин руу урссан олон гол горхи гээд нэн баян тансаг. Гэхдээ энд тариаланч, малчид цөөхөн. Гондорчууд голдуу Долоонхэрэмт хотдоо суудаг. Мөн Лоссарнахын өндөр уулсын хөндий, таван том түргэн урсгалт голоор умдаалдаг үзэсгэлэнт Лебеннинд суудаг билээ. Өмнөд уулсын ширүүн зант оршин суугчдыг уугуул гондорчууд гэж үздэг бөгөөд намхан нуруутай, бараан царайтай ч гэсэн аль дивангарт хаад Тэнгисээр хөвж ирэхээс ч өмнө тэнд суурьшсан цуутай омгийн удам юм. Гондорын өмнөд хязгаар Бельфалас хүн ам олонтой, энэ хязгаарын захирагч нь удамт ван Имраиль. Түүний өргөө Дол-Амрот Тэнгисийн эрэгт байдаг бөгөөд эндхийн хүмүүс нь чацархаг том биетэй, саарал нүдтэй ажгуу.

...Тэд цааш явсаар, тэнгэр нэлээд гэгээрч эхэллээ. Пин өндийж, эргэн тойрноо харав. Зүүн талд манан татаж, баруун талд уулс үргэлжлэх бөгөөд ертөнц үүсч байх үед хүчирхэг гол мөрөн дундуур нь тас татан урссан юм шиг эгц хажуутай, уулсын дунд ирээдүйн тулааны талбарыг бэлтгэсэн юм шиг уудам хөндийтэй ажээ. Тэдний өмнөөс Гэндэльфын ярьж байсан Миндоллуин хэмээх аварга уулс харанхуй дундаас сугаран гарч ирэх мэт хөндөлсөв. Дорно зүг харсан царам дэвсэг дээр нь Нуршгүй хот хэмээх нэртэй Долоон хэрэмт эртний хүчирхэг цайз орших бөгөөд түүнийг харахад барьсан биш, үлгэрийн аварга баатрууд хад чулуугаар цуггасан мэт санагдана.

Пин хэрмийн саарал хана үүрийн гэгээнээр цайран ягаарч, дараа нь нар харанхуйгаас гэнэт гарч ирээд чулуун хотыг хурцаар гийгүүлэхийг алмайран харж байв. Хэрмийн дээгүүр Эктелионы цамхаг сувдран гялалзаж, түүний орой болор адил гэрэлтэн туяарч, өглөөний салхинд цагаан тугууд дэрвэн, яндангууд мөнгөн бүрээ мэт цангинан цууриатахад Пин уулга алдан хашгирав.

Ингээд Гэндальф, Перегрин хоёр өглөөн нарны анхны туяатай хамт Гондорын нийслэлийн их хаалганы өмнө тулж очив. Тэдний өмнө ширмэн хаалга нээгдлээ.

- Митрандир! Митрандир! – хэмээн харуулууд дуу алдаж: - Тэгэхлээр аймшигт шуурга одоохон болох нь дээ! –гэцгээв.

- Аль хэдийн болдгоо болчихоод байна. Би тэр шуурганд хөөгдөж ирлээ. Зам тавиарай! Би танай эзэн Денэтортой хаана байгаа дээр нь уулзах гэж яарч байна. Юу л болвол болог, гэхдээ хуучин Гондор одоо байхгүй болсон гэж мэд. Зам тавь гэж би хэлсэн байх аа!

Харуулууд шидтэний агуу морин дээр эзнийх урд суусан хоббитыг ихэд гайхан харж байсан боловч юу ч асуулгүй, дуулгавартай зам тавьж өгөв. Эндхийнхэн адуу цөөхөн хардаг, хэрэв гудамжаар морьтой хүн явж байгаа бол төр улсын хойшлуулашгүй чухал хэргээр явж байгаа нь мэдээж байв. “Энэ морь жинхэнэ ристанийн талын адуу байх нь зайлшгүй! Магадгүй, мустангримчүүд бидэнд туслахаар яаран ирж байгаа юм болов уу” гэж хүмүүс дүнгэнэлдэв.

Аянга толгойгоо бардмаар өргөн, тахирласан урт замаар дээш өгслөө.

Минас-Тирит долоон давхар баригдсан бөгөөд уулыг долоо шатлан ороож, долоон хэрмээр хүрээлэгдсэн ажээ. Гадаад хэрмийн доод давхрын их хаалганууд дорно зүг рүү харсан, дараачийнх нь хаалганууд өмнө зүг рүү, гурав дахь давхрын хаалганууд хойт зүг рүү гэх мэт долоо дахь давхрын хаалга хүртэл ертөнцийн зүгүүд рүү дараалан харжээ. Хааны өргөөнд хүрэх чулуун зам нэг баруун тийш, нэг зүүн тийш эргэсэн байх бөгөөд их хаалгануудын дээгүүр өнгөрөхдөө нэгдүгээр давхраас бусад бүх давхруудыг хоёр хэсэгт хуваасан салаа хонгилоор гарах ажээ. Эртний мастеруудын хөдөлмөрөөр гүйцээж урласан эхний бүтээлийн оргил нь доод талбайн цаадах дорно зүг рүү тэмүүлсэн өндөр цохио бөгөөд яг л хөлөг онгоцны хитэг шиг харагдана. Долоо дахь хэрмийн дээрээс долоон зуун футийн доор байгаа их хаалгыг хөлөг онгоцны тавцан дээрээс харж байгаа юм шиг харж болох аж. Долоо дахь давхраас доод их хаалганы адил боловч арай бага хаалга бас дорно зүг рүү харжээ. Тэр хаалганд хадан цохиог нүхэлж, дэнлүүгээр гэрэлтүүлсэн урт хонгилоор хүрнэ. Хотоос Дээд хаалганд болон Усан оргилуурын талбайд хүрэх өөр зам байхгүй. Цагаан цамхаг тавин сажин өндөр, түүний оройд тал газраас дээш мянган фут өндөрт Гондорын туг намирч байлаа.

Энэ цайз үнэхээр автагдашгүй баг бэх, ямар ч дайсан давж орохооргүй, найдвартай харуул хамгаалалттай байв. Дайснууд ар талаас нэвтрэн орж, уул, цайз хоёрын хоорондох нарийхан хүзүүвчид хүрлээ гэхэд хүзүүвчийг найдвартай бэхэлж, баруун хавцлын захаар хаасан бөгөөд тэндхийн эль хуль хонхор газарт Гондорын эртний захирагчдын булш бунхан байдаг ажээ. Пин асар том цагаан чулуун хотыг гайхан бишрээд барсангүй, ийм хотыг зүүдэндээ ч үзэхгүй, энэ хотын дэргэд Изенгард юу ч биш гэж бодлоо. Өнгө үзэмжээрээ ч харьцуулшгүй. Гэвч энэ хот үнэндээ жилээс жилд хөгшрөн доройтож байжээ. Урьдахаас хоёр дахин цөөн хүн амтай, урьд нь ч тийм олон хүмүүс шахцалдаж байсангүй. Гудамжаар явахад байшин барилгын хаалга, нуман хаалгын дээр эртний рун бичгийг урнаар сийлсэн байх бөгөөд Пиний таамагласнаар бол тэдгээрийн эздийн нэр, цол бололтой, гэвч одоо тэдгээр орд өргөө нам гүм, өргөн шатаар нь хэн ч өгсч уруудахгүй, эзэнгүй өргөөнүүдэд нэг ч хүний дуу гарахгүй, сохор нүд мэт цонхнуудад хэний ч царай үл үзэгдэнэ.

Эцэст нь тэд хонгилоос долоо дахь давхрын хаалганд хүрэхэд Фродог Итилийн байгалийн сайханд гийгүүлж байсан нар голын цаанаас мандан хэрмийн гялгар хана, лужир том багануудаас ойж, их нуман хаалганы чулуун цоожийн дээр тусав. Гэндальф их яарч байлаа. Шилтгээнд морьтой оруулдаггүй учир Аянга эзнийхээ аяархан хэлсэн үгэнд орж, хамгаалагчдад чимээгүйхэн хөтлүүлэн одов.

Хаалганы дэргэдэх харуулууд хар цув, цахлай шувууны цагаан дүрстэй, орой дээрээ титэмтэй, урт чихэвч бүхий сонин дуулга өмссөн байх бөгөөд Гондор гүрнийг мандан бадарч байх үед мифрилээр давган хийсэн учир дуулганууд хурц тодоор гялалзаж харагдана. Цуван дээр нь цасан цагаан цэцэг бүхий мод, дээр нь мөнгөн титэм, одод дүрсэлсэн байна. Элендилийн хамгаалалтынхны өмсдөг энэ өмсгөлийг Гондорт зөвхөн нэгэн цагт Цагаан мод ургаж агсан Оргилуурт шилтгээний харуулууд л өмсдөг ажгуу.

Эндхийн харуулууд яагаад ч юм тэр хоёрыг хараад гайхсангүй, асууж байцаалгүй шууд оруулсан ба Гэндальф шилтгээний цагаан чулуун шатаар хурдан алхлан өгсөв. Тэртээ алсад тод ногоон нуга дахь усан оргилуур өглөөний нарны туяанд цацран оргилж, тунгалаг нууранд

нүцгэн мөчрүүдээсээ гашуудлын нулимс дуслуулах мэт хатсан мод бөхийжээ.

Пин Гэндальфын араас яарч явахдаа тэр мод руу эргэж хараад, эргэн тойронд ийм тансаг сайхан байхад ганц энэ хатсан мод яагаад ийм уйтгартай хачин харагдаж байгаа юм бол гэж гайхсан бүлгээ.

- Долоон од, долоон чулуу, цагаан мод.

Гэндальфын амандаа аяархан хэлсэн энэ өгүүлбэрийг Пин тогтоож аваад түүний алхааг гүйцэж ядан өгссөөр гэрэл цацарсан нэгэн цамхагийн үүдэнд хүрч, таг дуугүй зогсох харуулуудын хажуугаар өнгөрч, хагас харанхуй өндөр таазтай том танхимд орж ирэхэд Гэндальф Пинд:

- Хэлээ сайн хазаарай даа, эрхэм ноён Перегрин минь! Одоо хоббитуудын давсалж хачирласан яриа хэрэггүй. Энэ эзэн бол сайхан зант өвгөн Теоден биш. Огт өөр араншинтай, ихэмсэг бардам, заль ухаантай, өндөр дээд төрөлтэй, албан ёсны хаан гэгддэггүй ч их эрх мэдэлтэй Денэтор шүү. Тэр надтай ярихаасаа илүү чамтай ярина, хүү Боромирынх нь тухай юу мэдэж байгаа бүгдийг чинь асууна.

Тэр ууган хүүгээ маш их, магадгүй хэтэрхий их хайрладаг байсан юм, яагаад гэвэл Боромир түүнтэй юугаараа ч төсгүй байсан. Гэвч тэр хайр чамайг няц базахад саад болохгүй шүү, амаа мэдэж яриарай! Илүү үг нэгийг ч бүү хэл, Фродогийн даалгаврын талаар бүү дурс. Энэ тухай цаг нь болохоор би ярина. Арагорны талаар аль болохоор цөөхөн дурсаарай –хэмээн захив.

- Яагаад тэр вэ? Тэнэмэл юугаар муу юм бэ? Тэр наашаа ирэх гэж зүтгээгүй гэж үү? Тэр тэртэй тэргүй бидний араас хүрээд ирнэ шүү дээ! – гэж Пин шивнэн асуухад:

- Ирэх нь ч ирнэ. Гэхдээ хэний ч, бүр Дэнэторын ч санаанд орохгүй зүгээс хүрээд ирнэ. Тэр нь ч дээр. Хүрээд ирнэ гэж бодохгүй л байг. Тэр нь дээр. Тэрнийг ирж явна гэж бид хэлээд яахав.

Гэндальф гялтганасан хар гангаар бүрсэн өндөөр хаалганы өмнө зогслоо.

- Эрхэм хүндэт Пин гуай, Гондорын түүхийг чиний толгой руу чихэх нэг ч илүү минут алга. Чи өөрөө Хоббитаны ойд шувууны үүр хоосолж, цагийг хий дэмийн нөхцөөхийн оронд Гондорын түүхийг судлаарай. Хүн чамд юм хэлж байхад сонсч сур! Тэгээд өөрөө сайн бод. Хаан ширээ залгамжлах хүү чинь байхгүй болсон гэж хаанд хэлэх, далимд нь чиний хаан суудаг цаг дууслаа, хууль ёсны хаан нь ирж явна гэж мэдээлэх ямар байх вэ? Ойлгов уу?

- Хаа-ан? - гэж Пин гайхав.

- Тийм ээ, чихээ дэлдйилгэхээ болиод ухаанаа цэгцэл! – гэж Гэндальф хэлээд хаалга тогшив.

Хаалга өөрөө нээгдэж байгаа юм шиг аяндаа нээгдэхэд Пин хар гантиг багануудтэй, хоёр талдаа нарийн торон цонхтой асар том өргөөг харав. Эрдэнийн чулуун шигтгээт өндөр

хүнхэр тааз алтны өнгөөр бүдэгхэн туяарч, хээ угалзалсан навчис, араатны толгойнуудын дүрс ханануудыг бүрхжээ. Хөшиг ч байхгүй, баримал ч байхгүй, модон тавилга ч байхгүй. Багануудын хооронд догшин ширүүн дүрт хөшөөнүүд байна.

Тэдгээр хөшөө Андуины чулуун аваргуудыг санагдуулж байсан тул Пин аль дивангарт алга болсон Гондорын хаадын урт эгнээг сэтгэл догдлон харав. Өргөөний алсын буланд, олон гишгүүрт шатны дээр титэмт дуулган хэлбэртэй гантиг саравчин дор хаан ширээ байх бөгөөд арын хананд нь цэцэглэж буй модны дүрст эрдэнийн чулуун чимэг гялалзана. Гэвч хаан ширээний ард хэн ч алга. Шатны доод талын гишгүүр дээрх намхан чулуун сандал дээр өнө эртний өвгөн доош харан сууж байв. Тэр гартаа алтан унжуургатай цагаан очир барьжээ. Тэрбээр орж ирэгсэд рүү өндийж харсангүй. Хоёр гийчин түүнд аажуухан дөхөж очоод гурван алхмын зайтай зогсч, Гэндалф:

- Минас-Тиритийн эзэн бөгөөд захирагч, Эктелионы хүү Денэтор! Энэ бэрх цаг үед би чамд мэдээ авчирлаа, зөвлөгөө өгөхөд бэлэн байна.

Өвгөн толгойгоо өргөв. Пин догшин ширүүн дүртэй, ихэмсэг царай, урт бүргэд хамар, хөнхөр хар нүд харсан бөгөөд тэр өвгөн Боромиртэй огт адилгүй, харин ч Арагорныг санагдуулж байлаа.

- Цаг үе үнэхээр бэрх байна, чиний хамгийн дуртай цаг даа, Митрандир. Тийм ээ, Гондор ёроолгүй ангалын ирмэг дээр ирээд байна. Гэвч миний гуниг зовлон бүх нийтийн гуниг зовлонгоос гашуун байна. Чи миний хүүгийн үхлийн амьд гэрчийг авчирсан гэж сонслоо. Тэр чинь энэ үү?

- Тийм ээ, тэр энэ байна. Хоёр гэрч байсан юм. Нөгөөдөх нь Ристанийн Теодонтой ирэх байх. Хоёулаа одой биет, гэхдээ зөвлөлийн шийдвэрт эдний тухай байгаагүй.

- Эдний талаар байсан уу, үгүй байсан уу надад хамаагүй, гэхдээ манай зөвлөл огт ойлгомжгүй шийдвэр гаргаж, Боромир хаашаа ч юм бүү мэд, үхлийнхээ өдөөс ухаан жолоогүй зүтгэснээс хойш энэ үг миний чихэнд хангинах болсон юм. Хүү минь дээ, чамгүйгээр бидэнд мөн ч хэцүү байна даа! Фарамирыг явуулдаг байж дээ, би.

- Гунихдаа гунь, гэхдээ гуниг зовлонд шударга бай. Боромир өөрөө явахыг хүссэн, өөрийнхөөрөө зүтгэсэн. Эрх мэдэлтэй, дур зоргоороо тэр хүн үгнээсээ буцахыг тэвчдэггүй. Би түүнтэй олон бээр газар мөр зэрэгцэн туулсан учир түүнийг сайн таньсан юм. Чи түүний мөхлийн тухай дурслаа. Тэгэхлээр энэ тухай чамд мэдээлсэн байх нь ээ?

- Мэдээ нь энэ байна – гэж Денэтор хэлээд очироо хойш тавьж, өвдөг дээрээ байсан мөнгөн чимэгтэй эвэр бүрээг өргөж харуулав.

- Энэ чинь Боромирын бүрээ байна шүү дээ, тэр биенээсээ огт салгахгүй зүйж явдаг байсан юм! - гэж Пин дуу алдав.

- Тийм ээ, үүнийг урьд нь би зүүж явсан, Мардилын захирагчийн эцэг Ворондил алс руны талд араува зэрлэг бух агнаж явсан үеийн сүүлчийн хааны үеэс манай удмынхны ууган хүү

энэ бүрээг зүүдэг байсан юм. Арвангурав хоногийн өмнө вант улсын умард хязгаараас энэ бүрээ бүдэгхэн дуудахыг би сонссон. Их мөрөн надад эвдэрхий бүрээг авчирч өглөө. Дахиад энэ бүрээ дуугарахгүй – гээд Денэтор дуугүй болоход өргөөнд хачин нам гүм болов.

Тэгснээ Денотор Пин рүү нэвт шувт ширтэж

– Чи энэ талаар юу гэмээр байна даа, одой биет ээ?

- Арван гурав, арван гурав – хэмээн цаадах нь үглэснээ – тийм байна, арван гурван хоног юм байна. Тэр бүрээгээ үлээж байхад би дэргэд нь байсан. Гэвч тусламж ирээгүй, зөвхөн орхууд л дайраад ороод ирсэн.

- Аа, тийм юм биз дээ - гэж Денэтор Пиний нүүр рүү нүдээрээ шөвөгдөх мэт ширтээд - Чи түүний дэргэд байсан уу? Яриад бай, яриад бай! Яагаад тусламж ирээгүй юм бэ? Яагаад одой чи амьд гарсан, агуу хүчирхэг дайчин яагаад өмхий муу орхуудыг дийлээгүй юм бэ?

Пин дүрсхийж, айж байснаа мартав:

- Хамгийн агуу дайчинг ч нэг сумаар хөнөөж болно, харин Боромирын биед арваад сум туссан байлаа. Тэр мод түшин зогсоод, цээжнээсээ хар өдтэй сум суга татан гаргаж байсныг би санаж байна. Дараа нь би ухаан алдсан, намайг орхууд олзолсон. Дахиад би түүнийг хараагүй, өөр юу ч мэдэхгүй. Гэвч түүний тухай дурсамж надад үнэтэй, түүний гавьяа дурсгалтай. Тэр биднийг авраад амиа алдсан, намайг, бас миний найз Мериадокийн удмыг. Ой дотор биднийг Хар эзний цэргүүд отоож байсан юм. Тэр биднийг аварч чадалгүй амиа алдсан байсан ч би эцсийн өдрөө хүртэл түүнд талархах байсан.

Пин эрх мэдэл ихт, бардам өвгөний нүд рүү хараад гэнэт дорд үзсэн дээрэнгүй аястай үгэнд нь гомдож, бардам сэтгэл төрөв:

- Үлэмж биет хүмүүсийн хаан ширээний дэргэд умард Хоббитаний нэг муу одой биет юу юм бэ гэж бодож байна уу, болно оо, би тэртэй тэргүй өрөө төлнө. Миний амьдралыг авна уу – гээд Пин цувныхаа хормойг сөхөж, илдээ хуйнаас нь сугалаад Денэторын өлмий дор тавив.

Өвлийн оройн хүйтэн сарны туяа мэт инээмсэглэл өвгөний нүүрэнд тодорлоо. Тэр эвдэрхий бүрээг хажуудаа тавьж, гараа сунган:

- Зэвсгээ надад өгөөдөх! - гэв.

Пин илдээ авч бариулаар нь өвгөнд өглөө.

- Хаанаас чи авсан юм бэ? Аль дивангарт, мянган жилийн өмнө давтсан илд байна. Ир нь манай умард газрын давгалттай юм байна. Тийм үү, одой биет ээ?

- Манай орны умар зүгт байдаг булшнаас авсан юм. Тэр булшинд одоо зөвхөн үхдэлүүд л байгаа, би тэдний талаар цааш нь ярихгүй байсан нь дээр.

- Чи энэ богинохон насандаа их юм үзсэн толгой байх нь ээ - гэж Денэтор толгой сэгсрээд, -

Хүнийг шууд хараад таньж болохгүй гэж ярьдаг, одой хүнийг тэр тусмаа таних боломжгүй юм байна. За яахав, чиний хэлснээр амьдралыг чинь хүлээж авъя. Чи их бэлэн зэлэн үгтэй юм байна, чиний яриа биднийх шиг биш боловч бодолтой ярьдаг юм байна. Ухаантай, үнэнч хүмүүс цаашдаа бидэнд их хэрэг болно. Тангарагаа өргө дөө!

- Илдээ ав, нэгэнт шийдвэрээ гаргасан бол илдэн дээрээ гараа тавиад эзнийгээ дагаж тангаргын үгийг хэл - гэж Гэндалф хэлэв.

- Би шийдвэрээ гаргасан - гэж Пин хэлэв.

Өвгөн илдийг өвдгөн дээрээ тавьж, Пин бариул дээр нь гараа тавиад Денэторыг даган тангаргын үгийг давтав:

- Гондор улс болон энэ агуу хаант улсын эзэн захирагчид үнэнчээр зүтгэж, энх тайван, элбэг дэлбэг цагт ч, дайн байлдаан, гачигдал зовлонтой цагт ч, эзэн минь миний тангаргыг цуцлаагүй цагт, үхэл тангаргаас минь салгаагүй цагт, энэ ертөнц сөнөөгүй цагт эзнийхээ зарлигийг эрхэмлэн биелүүлж, дуугар гэхэд нь дуугарч, дуугүй бол гэхэд нь дуугүй болж, ир гэхэд нь ирж, яв гэхэд нь явж байхаа тангараглая. Хоббитаний одой хүн Паладиний хүү Перегрин би тангараглаж байна!

- Агуу хаант улсын эзэн захирагч, Эктелионы хүү Денэтор би тангаргыг чинь сонсч хүлээн авлаа, чиний тангаргыг би мартаагүй. Үнэнч зүтгэлийг чинь үнэлж, гавьяаг чинь хүндэтгэнэ. Тангаргаасаа няцвал цээрлүүлнэ.

Тэгээд Пин илдээ авч хуйнд нь хийв.

- За одоо миний анхны даалгаврыг биелүүл, юу ч нуулгүй бүгдийг ярь! Миний хүү Боромирын тухай юу ч нуулгүй, юу болсныг бүгдийг ярь! Суу, ярь!

Денэтор сандлынхаа хажууд байгаа мөнгөн цанг цохиход хаалганы хоёр талд үл үзэгдэгч зарц нар нь ил гарч зогсов.

- Дарс, хоол, зочдын суудал авчир, нэг цагийн турш хэн ч бидний ярианд бүү саад бол – гэж Денэтор тушаагаад... Би та хоёрт нэг цагаас илүү хугацаа гаргаж чадашгүй, яаралтай ажил хүлээж байна, яахав жаахан хүлээж л байг, харин оройхон тийшээ чамтай ярилцана – гэж Гэндалф хэлэв.

- Арай эртхэн ярилцана гэж найдаж байна. Би чамд ухаантай, үнэнч шинэ зарц авчирч өгөх гэж Изенгардаас энд хүртэл салхитай уралдаж ирээгүй. Теоден үхлийн тулаанд ялсан, Изенгард бут ниргэгдсэн, би Саруманы очырыг хугалсан. Ийм мэдээ чамд чухал биш гэж үү?

- Чухал байлгүй яахав. Энэ бүгдийг би хангалттай хэмжээнд мэдэж байгаа. Дорноос ирж яваа аюулыг сөрөхийн тулд мэдэх ёстой бүгдийг мэдэж байна.

Тэр Гэндалф руу харахад Пин энэ хоёр их эрх мэдэлт өвгөн хоорондоо их төстэй болохыг, бас бие биенээ огт таашаадаггүйг мэдрэв. Тэр хоёрын харц юу юугүй дүрэлзэн асах гэж

байгаа нүүрсний цог мэт улалзан байв.

Денэтор Гэндальфаас ч хүчирхэг шидтэн мэт харагдана. Ихэрхэг, бардам, илүү хөгшин ажээ. Гэвч Пинд Гэндальф түүнээс хүчирхэг, мэргэн санагдаж, түүний жинхэнэ агуу хүч одоохондоо нуугдмал байгааг мэдэрч байлаа. Тэр Денетороос хавигүй эртнийх билээ. “Хэдэн настай юм бол?” – гэж бодоод Пин гайхлаа. Яагаад ч юм урьд нь ийм асуулт түүний толгойд орж байгаагүй ажээ. Шидтэнүүдийн тухай яриа зөндөө л сонсч байсан боловч тийм яриа Гэндальфын тухай биш байжээ. Ер нь Гэндальф гэж хэн юм бэ? Тэр хэзээ, ямар мартагдсан эринд энэ ертөнцөд ирсэн юм бэ, хэзээ буцах юм бэ? Бодлоосоо сэрсэн Пин нэг харахад Денэтор, Гэндальф хоёр бие биеийнхээ бодлыг уншиж байгаа мэт өөд өөдөөсөө ширтэлцэж байв. Денэтор түрүүлж харцаа буулгаад:

- Тийм дээ, ертөнц дээр нүдтэй чулуу байдаггүй гэдэг боловч Гондорын эзэд урьдын адил хурц хараатай хэвээрээ байна, тэдэнд олон замаар мэдээ ирдэг юм. Суу л даа!

Зарц нар жижиг ширээ, буйдан сандал, нэг жижиг сандал авчирч тавилаа. Ширээн дээр мөнгөн домботой умдаа, цагаан талх тавилаа. Пин өвгөн захирагчаас нүд салгалгүй суув. Тэгж санагдсан уу, үнэхээр тэгсэн үү, бүү мэд, Денэтор чулуу гэж хэлэхдээ Пин рүү хяламхийх шиг болжээ.

- За яриад бай даа, үнэнч албат минь, - гэж Денэтор өршөөнгүй инээвхийлээд – миний хүүтэй тийм дотно нөхөрлөж байсан хүний үг болгон надад жинхэнээсээ үнэтэй – гэлээ.

Гондорын эзэн захирагч хүнд бөгөөд аюултай асуулт байн байн тавьж, нүдээрээ өрөмдөх мэт нэвт шувт ширтэн, дэргэд нь Гэндальф суугаад уур хилэнгээ арайхийн дарж, тэвчээртэй сонсч суусан тэр мөчүүд Пиний ой тойнд хэзээ ч мартагдахааргүй хадагдан үлджээ.

Эцэст нь цаг дуусч, Денэтор цангаа цохиход Пин арай гэж амьд салав. “Дөнгөж есөн цаг болж байна, одоо гурван хүний хоол идэх юмсан!” – гэж тэр бодлоо.

- Манай зочин Митрандирыг түүнд бэлтгэсэн өргөөнд оруул, хэрэв дагуул нь түүнтэй хамт байхыг хүсвэл хамт оруул – гэж Денэтор тушаагаад – Аа тийм, тэр одоо миний албат болсон, Паладины хүү Перегрин гэдэг юм. Түүнд нэгдүгээр нэвтрэх үнэмлэх өгөөрэй. Жанжингуудыг гурав дахь цаг дуусахад хаалганы дэргэд намайг хүлээж бай гэж дамжуул – гэв.

Тэгээд Гэндальфт хандаж: - Эрхэм эзэн Митрандир, бас энэ цагт ирээрэй, хэрэв түүнээс эрт ярилцахыг хүсвэл хүссэн цагтаа ирээрэй. Миний нүдний хор гаргах богинохон цагаас бусад цагт чамайг нэвтрүүлнэ. Зөнөг өвгөний тэнэглэлд бүү хилэгнээрэй, ирж сэтгэлийг минь тайтгаруулаарай!

- Зөнөг өвгөний тэнэглэл гэв үү? – гэж Гэндальф асуугаад - Үгүй ээ эзэн минь, чиний ухаан сав саруулаараа байна, зөнөнө гэдэг чиний хувьд үхсэнтэй ялгаагүй. Уй гунигаа их зальтай хаацайлж байх шив! Надаас хамаагүй бага юм мэдэж байгаа гэрчийг яагаад бүтэн цаг байцаасныг чинь би мэдээгүй гэж бодож байна уу?

- Ойлгосон бол сайн байна - гэж Денэтор хэлээд – Хүнд бэрх цагт тусламж, зөвлөгөөнөөс

таггалздаг бардамнал бол ухаангүй бардамнал, гэхдээ чи өөрийнхөө далд санааны үүднээс тусалж, зөвлөдөг шүү дээ. Гондорын эзэн хичнээн сайн санааных байсан ч бусдын зорилгод үйлчилдэггүй. Өнөөдөр энэ ертөнцөд Гондорыг аврахаас эрхэм зорилго байхгүй, энэ орны жинхэнэ хууль ёсны удирдагч ирэх хүртэл энэ орныг өөр хэн ч биш, би л захирна.

- Жинхэнэ хууль ёсны удирдагч ирэх хүртэл үү? - хэмээн Гэндальф түүний үгийг шүүрч аваад: - Үнэхээр тийм шүү, эзэн захирагч минь, чи хэний ч үл мэдэх хугацаагаар чамд найдаж хариуцуулсан энэ хаант улсыг хамгаалах болно. Энэ үйл хэрэгтээ чи хүссэн бүх тусламжаа авах болно. Гэвч би чамд нэг юм хэлье. Би Гондорын эзэн захирагч биш, их бага ямар ч газар орныг захирдаггүй. Гэвч би өнөөгийн энэ ертөнцөд аварч хамгаалах ёстой юм бүхнийг хариуцна. Гондор улс үгүй боллоо ч гэсэн би үүргээ биелүүлнэ. Харанхуй сарних цагт дэлхийн сайн сайхнаас ямар нэг юм үлдлээ гэхэд, хэн нэгний төлөө цэцэг ургаж, үр жимс боловсорлоо гэхэд би үүргээ биелүүлнэ. Би ч гэсэн эзэн захирагч. Чи үүнийг мэдээгүй гэж үү? – гээд Гэндальф эргэж өргөөнөөс гарахад Пин дагаж гүйв.

Замдаа Гэндальф нэг ч удаа Пин рүү харсангүй, нэг ч үг хэлсэнгүй. Тэр хоёрыг оргилуурт талбайгаар дагуулан явж, өндөр өндөр чулуун барилгуудын дундуурх нарийхан гудамж руу оруулав. Хэдэн ч удаа эргээд хүзүүвчнээс холгүй хэрмийн хойт ханын дэргэдэх байшинд орлоо. Өргөн гантиг шатаар хоёрдугаар давхарт гарч, гэрэлтэй, саруулхан өргөөнд орлоо. Алтлаг хөшигний завсраар нарны туяа тусч байна. Өргөөн дотор жижиг ширээ, хоёр сандал, хоёр талын хананд зассан ор, дэргэд нь домботой ус, угаалгын түмпэн байна. Гурван нарийхан цонх нь хойт зүг рүү харсан бөгөөд тэртээ алсад мананд хучигдсан Андуин, түүний цаана Жалгат уул, түүнээс цааш Рэросын хүрхрээ харагдана. Пин цонхонд хүрэхгүй байсан тул сандал дээр гарч харав.

- Гэндальф, чи надад уурлаагүй биз дээ? – гэж тэр дагуулж ирсэн хүнийг гармагц асуугаад. Би их хичээсэн шүү - гэлээ.

- Хичээсэн, хичээсэн! – гэснээ Гэндальф гэнэт инээд алдаж, цонх руу дөхөж ирээд Пиний дэргэд зогсон мөрөөр нь тэврэхэд Пин түүний нүүр рүү гайхан харав. Тэр ийм хөгжилтэй, санаа амар инээж байна гэж үү дээ? Үгүй дээ, тийм байх ёсгүй. Өвгөн шидтэний царай уйтай, санаа нь зовнисон шинжтэй байв. Гэвч сайтар харвал түүний уйтгарт царайны цаана асар их далд баяр хөөр байгааг Пин мэдэрч, тэр баяр хөөр нь гадагшаа халин гарч ирвэл хаант улс тэр чигээрээ элгээ хөштөл инээх юм шиг санагдав.

- Тийм ээ, чи үнэхээр хичээсэн, чи удахгүй дахиад саяных шиг хоёр аймшигт өвгөний хооронд хавчуулагдана гэж найдаж байна. Гэхдээ чи яаж ч хичээлээ гэсэн Гондорын эзэн чиний бодож байгаагаас илүү ихийг чамаас шахаад гаргачихлаа. Танай бүлгийг Мориугоос Боромир биш, Минас-Тирит рүү явж байгаа нэгэн их эрх мэдэлтэй баатар ван удирдаж явсаныг, түүнд домог болсон алдартай илд байсныг чи нууж чадсангүй. Гондорт өнө эртний домгууд их бий, Денэтор дотроо Боромирыг үдэхдээ багагүй бодож байж “Исилдурын хараал” гэдэг үгийн утгыг тайлж амжсан.

Тэр ер нь өнөөгийн хүмүүстэй дүйцэхгүй их ухаантан байгаа юм. Пин минь, цусаараа биш гэхэд үзэл санаагаараа тэр жинхэнэ нуменорын удмын хүн, түүний бага хүү Фарамир ч гэсэн ялгаагүй, Боромирт аав нь дэндүү хайртай байсан ч Фарамир энэ талаар ахаасаа илүү. Тэр их

ухаалаг, хүнийг хараагүй ч гэсэн сайн таньдаг. Түүнийг мэхлэх хэцүү, оролдохын ч хэрэггүй.

Тэгэхлээр хүү минь тэсээд л байж дээ, чи эдэнтэй тангаргаар бат холбогдсон. Яагаад чиний санаанд ийм юм орсныг мэдэхгүй, бодвол сэтгэл зүрх чинь хэлж өгсөн биз.

Гэхдээ цагаа олсон шийд байсан, тэгээд ч сэтгэл зүрхний сайхан тэмүүллийг саруул болгоомжлолоор унтрааж болохгүй. Чи тэрний сэтгэлийн утсыг хөндсөн, түүнд их таалагдсан байж ч магадгүй. Ямар ч гэсэн чи одоо албаныхаа чөлөө заваар Минас-Тиритээр чөлөөтэй зугаалж болно. Албанд чөлөө зав бага байдаг, чи одоо түүний албат, тэр чамайг мартахгүй. Болгоомжтой бай!

Тэр дуугүй болж, санаа алдав.

- Маргааш юу болохыг тааж яах юм бэ? Өдрөөс өдөрт аймшигтай болно, би юуг ч урьдаас зайлуулж чадахгүй. Тоглоом явж байна, хүүнүүд хөдөлж байна. Зөвхөн нэг л хүү үзэгдэж харагдахгүй байна, өнөөгийн захирагч Денэторын хүү Фарамир. Хотод байхгүй юм шиг байна, надад асуух ч зав гарсангүй, хэнээс ч асуух юм билээ. Би одоо явах хэрэгтэй, Пин минь, жанжингуудын зөвлөгөөнд сууна, тэнд мэдэж болох бүхнийг мэдэж авна. Тоглоомыг Дайсан удирдаж байгаа, тэр өөрийгөө хүлээлгэдэггүй. Хүүнүүд хүүнүүдтэй эн тэнцүүхэн тоглож байна, чи өөрөө үзнэ ээ, Паладины хүү, Гондорын дайчин Перегрин минь, Илдээ хурцал!

Хаалган дээр очоод Гэндальф эргэж харав:

- Би яарч байна, Пин, чамаас гуйх нэг юм байна. Чи тийм ч их ядраагүй гэж бодож байна. Амрахаа түр азнаад Аянгыг эргээрэй, тэнд яаж амрааж байна? Түүнийг гомдоохгүй л дээ, эндхийн хүмүүс ухаалаг, гэхдээ адуунд дасаагүй улс.

Гэндальфыг гарахад гол цамхаг дээрх хонх чангаар жингэнэв. Мөнгөн хонхны дуу гурвантаа цуурайлсан нь нар мандсанаас хойш гурав дахь цаг дууссан дохио ажээ.

Пин шатаар бууж, гудамжинд гараад эргэн тойрноо харав. Нар дулаахан, тод туяаран, цамхагууд болон өндөр байшингууд урт, тод сүүдрээ унагажээ. Цасан өмсгөлт Миндоллуины оргил цэлмэг тэнгэрт сүндэрлэнэ. Дайчид гудамжаар өнгөрч, харуул солигдож байгаа бололтой.

- Манайхаар одоо өглөөний есөн цаг, - гэж Пин өөртөө хэлэв. – Хавар, нар, - нээлттэй цонхны дэргэд суугаад өглөөний цайгаа уудаг даа. Энд ч гэсэн өглөөний хоол идэхэд яадаг юм бэ! Өдийд идэцгээчихээ биз дээ. Харин хэзээ, хаана өдрийн хоолоо иддэг нь сонин байна?

Оргилуурт талбайгаас нааши нарийхан гудамжаар хар-цагаан алагласан хувцастай хүн ирж явна, Пин тэр хүнтэй уулзахаар шийдтэл тэр өөрөө хүрээд ирэв.

- Чи нөгөө жижиг биет Перегрин үү? Чамайг манай эзэн болоод улс гүрэнд үнэнчээр зүтгэхээ андгайлсан гэж надад хэлсэн. Сайн байна уу! – гээд тэр хүн гараа өгөхөд Пин гар

барилаа.

- Миний нэр Боранорын хүү Берегонд. Өнөө өглөө би чөлөөтэй болж, намайг чамд нэвтрэх үнэмлэх өг, мэдэх ёстой бүгдийг хэлж өг гэж явууллаа. Би ч гэсэн чамаас олон юм мэдэж авмаар байна, урьд нь манайд жижиг биет ирж байгаагүй, тэдний тухай чихнийхээ үзүүрээр л сонссон. Тэгээд ч чи Митрандирын найз шүү дээ. Чи түүнийг сайн мэдэх үү?

- Юу ч гэмээр юм бэ дээ. Би өлгийтэй байхаасаа л түүнийг мэднэ, гэхдээ энэ чинь богино хугацаа шүү дээ, одоо хамтдаа аялж явна. Нэг их том номны нэг хуудсыг л уншсан юм шиг. Гэхдээ түүнийг сайн мэддэг хүн тун цөөхөн дөө. Манай отрядаас ганц Арагорн л түүнийг жинхэнээр мэддэг байх.

- Арагорн гэнэ ээ? Тэр чинь хэн юм бэ?

- Нэг тийм хүн бидэнтэй хамт явж байсан юм – гээд Пин түгдэрч, - одоо Ристанид байгаа байх аа.

- Чамайг Ристаниас шууд наашаа ирсэн гэж би сонссон. Ристанийн талаар чамаас асууя гэж бодсон юм. Бидэнд найдвар бага байна, хамаг л найдвар маань Ристани болж байх шив дээ. Ингэхэд юуны өмнө чиний асуултад хариулахыг надад даалгасан. Асуугаад байгаарай, эзэн Перегрин!

- Юу л даа – гэж Пин зориг ороод, - Үнэнийг хэлэхэд одоо миний толгойд нэг л асуулт эргэлдээд байна, өглөөний хоол ч юм уу, ямар нэг идчихмээр юм байна уу? Өөрөөр хэлбэл танай энд хэзээ хоолоо иддэг юм бэ, хоолны газар хаа нэгтээ байгаа биз дээ? Мухлаг ч юм уу, нэг тиймэрхүү газар байдаг биз дээ? Би замдаа тийм газар огт үзээгүй, зүдэрсэн болохоор гүүрүүшиг пиво уух юмсан гэж их бодлоо, ямар зэлүүд газар биш, том хотод ирсэн шүү дээ!

Берегонд түүн рүү ширүүн харав.

- Ёстой их юм үзсэн цэрэг гэдэг нь илт байна. Аян дайнд явж байгаа цэрэг дараачийн удаа хаана идэж уух бол гэсэн ганцхан л юм боддог гэж ярьцгаадаг юм. Би өөрөө алсын аянд явж байгаагүй болохоор хүмүүсээс л сонссон юм. Тэгэхлээр өнөө өглөө чи намуу цэцгийн шүүдэр балгаагүй байх нь ээ?

- Балгах нь ч балгасан л даа – гэж Пин үнэнээ хэлээд: - Хундага дарс уусан, хоёр зүсэм талх идсэн. Танай эзэн биднийг дайлсан юм, гэвч намайг бүтэн цаг байцаасан болохоор өөрийн эрхгүй л өлслөө шүү дээ.

Берегонд тачигнатал инээв.

- Жижиг биетэн хоолны ширээний ард баатар гэж манайхан ярьдаг юм. Чи өглөөний өлөнгөө цайзын ямар ч дайчнаас дутуугүй тайлсан байна шүү дээ, тэгэхдээ ямар их хүндтэйгээр гээч. Бид цайзад байна, бид түүнийг хамгаалж байна, дайны цаг шүү дээ. Шөнөөр босч, үүрээр хооллоод байр байраа эзэлдэг. Санаагаар унахаа азнаж үз! – гээд Пиний урвагар царай руу харснаа дахин хөхөрч: - Бусдаас илүү бэрхийг давсан хүмүүст өглөөний хоолноос нэг удаа

илүү хооллохыг зөвшөөрдөг юм. Дараа нь өдрийн хоол иднэ, гэхдээ өдөр ч байж болно, орой ч байж болно. Явцгаая! Жаахан алхацгаая, ямар нэг идэх юм олъё, хэрмэн дээр суугаад идэж ууж, орчныг сонирхоё, ямар сайхан өглөө болж байна вэ.

- Хүлээгээрэй! - гээд Пиний царай улайж: - Шуналаасаа болоод гэж бодно уу, өлссөнөөсөө болоод гэж бодно уу хамаа алга, би нэг юм мартчихаж. Гэндалф, танайхаар бол Митрандир өөрийнхөө морь Аянгыг эргээрэй гэж захисан юм. Тэр бол Ристанийн хамгийн хурдан морь, Ристанийн хаан тэр мориндоо ухаангүй хайртай байсан боловч Митрандирын агуу их гавьяаг үнэлж, шагнал болгож өгсөн юм. Митрандир мориндоо их хайртай, танай хотынхон Аянгын шинэ эзнийг хүндэтгэдэг бол энэ морийг хүндэлж асраарай, нэг үгээр хэлэхэд энэ моринд өлсгөлөн хоббитоос илүү анхаарал тавиарай.

- Хоббит гэж хэн юм бэ?

- Бид өөрсдийгөө ингэж нэрлэдэг юм.

- Баярлалаа, мэдэж авъя. Харийн хүмүүс хоббитуудаас ухаалаг харьцаа, уран үг сурмаар юм байна даа. Явцгаая! Чи намайг тэр гайхамшигт морьтойгоо танилцуулж өг. Би амьтдыг их хайрладаг. Манай энэ хатуу чулуут хөрстэй газарт мал, амьтан цөөхөн. Гэхдээ миний өвөг дээдэс уулын хөндийд нутагладаг байсан, түүнээс өмнө Итилд нутагладаг байсан юм. Бүү хамраа унжуул, морийг чинь харчихаад тэндээсээ шууд агуулах орё.

Аянгыг хэрмийн зургаа дахь давхарт, маш тохилог жүчээнд оруулжээ. Тэнд Денэторын болон жанжингуудын яаралтай чухал даалгаврыг биелүүлэхээр бэлэн байлгаж байдаг улсын чухал албаны хурдан морьдын жүчээ байна. Одоо тэр жүчээнд нэг ч морь алга, бүгдийг ийш тийш илгээжээ.

Аянга Пинийг хараад янцгааж, өөдөөс нь дөхөв.

- Өглөөний мэнд! – гэж Пин түүнтэй мэндлээд – Гэндалф завтай болонгуутаа ирнэ, тэр одоо ажилтай байгаа. Тэр чамд мэнд дамжуулсан, холын бэрх замыг туулж ирсний дараа сайн амарч байна уу, бүх зүйлд сэтгэл хангалуун байна уу, мэдээд ир гэж надад даалгасан юм.

Аянга дэлээ сэгсрээд, туурайгаараа газар цавчив. Гэвч Берегондод өөрийг нь илэхийг зөвшөөрлөө.

- Энэ морь холын бэрх замыг туулж ирсний дараа сайн амраагүй, эзнээ хүлээгээд л зогсч байгаа юм шиг байна даа. Ямар хүчирхэг биетэй юм бэ! Тоног хэрэгсэл нь хаана байна? Их л гоё, тансаг эд байгаа байх даа!

- Энэ моринд тохирохоор тийм тансаг гоё биш ээ, тэгээд ч тийм тансаг тоногоор яах юм бэ? Эзэнд нь л таалагдаж байвал эмээл хазаар ч яамай. Эзэнд нь таалагдахгүй бол ямар ч эмээл, хазаар, олом жирэм, амгай зуузай тус болохгүй. Баяртай Аянга! Жаахан тэсч бай, удахгүй тулаанд мордоно.

Аянга толгойгоо өргөн чангаар янцгаахад жүчээ доргиж, мань хоёр чихээ дарав. Тэр хоёр

морины онгоцонд үр тариа хийчихээд явлаа.

- Одоо өөрсдийнхөө тэжээлийн онгоцон дээр очъё - гэж Берегонд хэлэв. Тэгээд хоёул цайз руу буцаж, цамхгийн хойт хаалганд хүрч, сэрүүхэн урт шатаар буугаад дэнлүүнүүд зүүсэн өргөн хонгилд оров. Эгнэсэн намхан хаалгануудын нэг нь нээлттэй байлаа.

- Энэ бол манай сумангийн агуулах, түгээгүүр - гэж Берегонд хэлээд – Сайн уу, Таргон! Одоо ч эрт л байна л даа, гэвч надтай шинэ дайчин явж байна, эзний зарлигаар хүлээж авсан юм. Тэр урт замд өлсч ундаассан, өнөө өглөө түүний хувьд хүнд байсан юм. Ямар нэг идэх юм аваад ир! – гэж хаалга руу хашгирав.

Тэр хоёрт талх, шар тос, бяслаг, намар нөөцөлсөн сэнгэнэм сайхан амттай алим, ширэн дашмагтай шинэхэн пиво, бас модон аяга өгөв. Тэр хоёр бүгдийг сагсанд хийж бариад дээш гарав. Берегонд Пинийг хэрмийн зүүн тал руу дагуулан явж, чулуун сандал дээр сууцгаалаа. Алсад өглөөн наранд гялалзсан уудам хөндий харагдана.

Тэр хоёр идэж уунгаа Гондорын тухай, эндхийн ажил хэрэг, зан заншилын тухай ярьж, дараа нь Хоббитаны тухай болон Пиний аялсан газар орны тухай ярилцав. Ярих тусам Берегонд улам л гайхаж, сандал дээр суугаад богинохон хөлөө савчуулан ярьж буй хоббит руу нэг харж, нэг босч хэрмийн шагайвчаар харна.

- Чамаас нуугаад яахав, Перегрин минь, чамайг анх харахад авч ч болохгүй, хаяж ч болохгүй есөн настай хүүхэд шиг харагдсан, гэтэл чи өчнөөн олон аюулыг давж, манай буурал сахалт өвгөн л үзсэн баймаар өчнөөн олон гайхамшгийг үзжээ. Би дээр үед хаадын өргөөнд байсан гэж ярьдаг алиа салбадай манай эзэн захирагчид хэрэг болсон юм байх гэж бодсон шүү. Тэгсэн чинь огт өөр хүн байдаг байна, миний мунхгийг юманд битгий бодоорой.

- Яалаа гэж. Чи нэг их алдсангүй. Манайхны ёсоор бол би жинхэнэ хүүхэд, дөрвөн жилийн дараа л манай Хоббитанд ярьдгаар “насандаа орно”. Ер нь миний талаар ярихаа больё, алив үзүүлээд, тайлбарлаад бай.

Нар өндөрт мандаж, хөндийн манан сарнилаа. Манангийн сүүлчийн тасархайнууд тэнгэрт хөөрч, дорнын салхинд хэрэм дээрх цагаан дарцгууд дэрвэнэ. Тэндээс таван бээрийн зайд нүд хүрэх газарт Их мөрөн сааралтан гялалзаж, өмнө зүг рүү тэмүүлэн нүднээс алдарч байв. Тэнгис хүртэл дахиад тавь гаруй бээр урсах ажээ.

Пеленнор бүхэлдээ алган дээр байгаа юм шиг ил харагдаж байв. Хаана ч үхэр мал бэлчиж харагдахгүй мөртөө хашаа бүхий эдлэн газрууд, амбаарууд, үхэр малын хашаа саравчнууд энд тэндгүй үзэгдэнэ. Ногоон талыг их бага замууд хөндлөн гулдгүй огтолж, Их хаалга руу жингийн цуваа хөврөх ба өөдөөс нь бас тийм цуваанууд ар араасаа хөвөрнө. Хааяа нэг морьтой хүмүүс хот руу давхин орж харагдана. Их хаалганаас гарсан их зам өмнө зүг рүү огцом эргээд, уулын бэл даган хөвөрсөөр үзэгдэхгүй болжээ. Их зам өргөн бөгөөд чулуун хавтангаар тавьсан, далангийн хажуугаар морьтой хүмүүст зориулсан ногоон зам байна. Тэр замаар морьтнууд нааш цааш давхилдаж, их зам нь явган хүмүүсээр үерлэж байх шиг харагдана. Дараа нь Пин сайтар ажиглаад их зам дээр нарийн дэг журам байгааг үзэв. Хөдөлгөөн гурван эгнээгээр үргэлжлэх бөгөөд нэг нь хурдан, морин тэрэгтэй, нөгөө нь арай

удаан, шар хөллөсөн олон өнгийн нүсэр бүхээгт тэрэгнүүд, гурав дахь нь хамгийн удаан, тэрэг чирсэн явган хүмүүс ажээ.

- Тумладены хөндий, Лоссарнахын хөндий рүү явцгааж байна, уулын суурингууд, тэндээс цааш Лебеннин рүү явж байна, - гэж Берегонд тайлбарлаад – хөгшид, хүүхэд, эмэгтэйчүүдийн сүүлчийн цуваанууд. Үд дунд гэхэд хотоос гарсан зам нэг бээр зайд чөлөөтэй болсон байх ёстой. Тийм тушаал өгсөн, яая гэхэв! – гээд тэр санаа алдаж: - Салж хагацсан хүмүүсээс цөөхөн нь эргэж уулзана даа. Манайхан ер нь хүүхэд цөөтэй, одоо бол миний хүү шиг арай ахмад хөвгүүд л үлдсэн, яахав дээ, хэрэг болох ч магад.

Тэр хоёр дуугүй хэсэг суув. Пин орхуудын хар цуваа одоохон гараад ирэх гэж байгаа юм шиг зүүн зүг рүү түгшүүртэй харж байлаа.

- Тэнд юу байна аа? – гээд тэр Андуины дунд хавь руу зааж – Тэнд өөр хот байгаа юм уу? – гэж асуув.

- Өөр хот байсан юм, Гондорын нийслэл, манай Минас-Тирит бол ердөө л харуулын цайз. Тэнд, Андуины цаана Осгилиатын балгас л байгаа, дайснууд аль хэдийн эзэлж аваад шатаачихсан юм. Бид Денэторыг залуу байхад нийслэлээ дайснуудаас булааж авсан, гэхдээ тэнд суурьшаагүй, тэргүүн шугамын бэхлэлт болгож, нэмэлт хүч явуулахын тулд гүүр барьсан юм. Гэвч Минас-Моргулаас заналт морьтнууд довтолсон.

- Хар морьтнууд уу? – гэж Пин нүдээ бүлтийлгэн асуув. Түүнд саяхны айдас санагджээ.

- Тийм ээ, тэд хар байсан, чи түрүүн энэ талаар яриагүй боловч тэднийг сургаар мэдсэн биш юм аа даа.

- Тийм ээ, сургаар мэдээгүй, - гэж Пин аяархан хэлээд – Харин одоо тэдний тухай ярихгүй байсан нь дээр, тэд маш ойрхон байгаа...

Тэр үгээ тасалж, голын цаад тал руу харав. Тэнд маш том, нэг л зэвүүн хар сүүдэр нэлийж байлаа. Магадгүй, манантах алсад байгаа уулсын сүүдэр туссан юм уу, эсвэл үүл хана мэт ханарсан юм уу, гэвч тэр сүүдрийн цаана тас харанхуй харагдав. Тэр харанхуй харсаар байтал мөлхөн тэлж, нарлаг орон зайг удаан бөгөөд эргэлтгүй дүүргэж байх шиг санагдав.

- Мордороос ойрхон гэж үү? - хэмээн Берегондоос асуухад цаадах нь тайвнаар

– Тийм ээ, ойрхон байгаа. Нэрийг нь хэлэхээс бид зайлсхийдэг юм, бид мэдээ орсон цагаасаа л түүний хар сүүдэрт амьдарч байна. Заримдаа шингэрч, цаашилдаг, заримдаа өтгөрч наашилдаг. Одоо тас хар болж, өргөсөн тэлээд байгаа юм, тэгээд л бид айж түгшээд байгаа юм шүү дээ. Заналт морьтнууд жил орчмын өмнө гарам руу дайрч, тэнд манай олон шилдэг дайчид амь үрэгдсэн дээ. Тэгэхэд Боромир тэднийг хөөж, баруун эргийг чөлөөлсөн, тэгээд л одоо бид Осгилиатын бараг талыг барьж байгаа юм. Гэвч тэд өнөө маргаашгүй дахин довтолно. Тэндээс л дайн эхлэх байх, тэндээс л гол цохилт ирэх байх.

- Хэзээ эхэлнэ гэж? Өнөө маргаашгүй гэж чи бодож байна уу? Шөнө би дохионы галууд асч,

мэдээчид давхилдаж байхыг харсан. Гэндальф дайн эхэлсний тэмдэг гэж хэлсэн. Тэр түймэр унтраах гэж байгаа юм шиг л яараад байсан. Харин одоо дахиад чимээгүй болох шиг.

- Дайсны бүх юм бэлэн болсон, тэгээд л чимээгүй болж байгаа юм. Шумбагч хүн урт амьсгаа авч, агаар хуримтлуулдаг шиг.

- Дохионы галыг яагаад өчигдөр асаасан юм бэ?

- Дайсан дайраад ороод ирсэн хойно тусламж дуудах оройтно - гээд Бергонд мушийн инээмсэглээд – Эзэн захирагч болон жанжингууд юу яаж сэтгэснийг би мэдэхгүй. Тэдэнд л бүх мэдээ ирдэг. Манай эзэн захирагч Денэтор бүхнээс холыг хардаг, харагдахгүй юмыг ч хардаг. Шөнийн цагаар цамхагийн оройд гарч суугаад ирээдүйд санаа бодлоороо нэвтэрдэг, заримдаа Дайсны санааг мэдэж, тэрэнтэй бодлоороо тулалддаг гэж ярьдаг юм. Тэгээд л цагаасаа эрт хөгширсөн юм. Фарамирыг мөрний цаад руу илгээсэн. Түүнээс мэдээ ч ирсэн байж болох юм.

Гэвч өчигдөр Лебеннинээс мэдээ ирсний дараа дохионы гал асаасан гэж бодож байна. Умбарын дээрэмчид Андуинд маш том флот тавьсан гэсэн. Тэд Гондороос аль эрт айхаа больчихоод байгаа юм. Дайсантай сүлбэлдсэн. Энэ бол бидний хувьд аймшигтай цохилт. Энэ бол Лебеннин болон Бельфаласаас тусламж ирнэ гэж хүлээсний хэрэггүй гэсэн үг, олон мянган туршлагатай дайчид ирэхгүй болно. Бидэнд умардаас, Ристанаас тусламж ирнэ гэж найдаад тэндхийн ялалтын тухай чиний мэдээнд баярлаж суух л үлдэв шив.

Гэвч - гээд тэр босч, дөрвөн зүг рүү харснаа – Изенгардын урвалтаас хойш Дайсан асар том тор нэхэж, их өргөн тэлсэн нь тодоос тод болсон. Гарам дээрх тулалдаан, Игил, Анориэнээс довтолсон, отолт, энээ тэрээ бол ердөө л түншиж үзсэн хэрэг. Одоо дээд зэргээр бэлтгэсэн дайн эхэлж байна. Энэ бол зөвхөн бидний эсрэг дайн биш, агуу их, бүх дэлхийн дайн. Дорно зүгт, Дотоод тэнгисийн цаана байдал таагүй болсон гэгцгээж байна, умар зүгт, Балар шугуйд ч гэсэн байдал муу байгаа гэнэ, өмнө зүгт, Хородод бүр ч ярих юм байхгүй. Одоо бүгдэд нэг л хувь заяа нүүрлэж, бүгдийг хар сүүдэр нөмөрлөө. Нэг бол тэсэх, нэг бол үгүй болох хоёрхон зам л байна.

Гэвч бид бусдаас онцгой нэр хүндтэй, Хар эзэн биднийг бүр аль дивангараас, тэнгисийн цаадах эринээс бусдаас илүүгээр үзэн ядаж ирсэн юм. Тэр бидэн дээр тун ч хүнд цохилт буулгана даа, эрхэм Перегрин минь. Тийм ч учраас Митрандир наашаа хамаг хурдаараа давхиж ирсэн. Хэрэв бид унаад өгвөл хэн дайсны өөдөөс тэсэх юм бэ? Юу гэж бодож байна, эрхэм Перегрин, бид тэсэх болов уу, найдвар байна уу?

Пин хариу хэлсэнгүй. Тэрбээр хүчирхэг хана хэрэм, бардам өндөр цамхагууд, дэрвэж буй тугнууд руу хараад дараа нь тэнгэр, нар өөд, дараа нь зүүн зүг рүү, мөлхөж буй харанхуй руу хараад, бүхнийг залгигч сүүдэр, ой болон ууланд язганаж байгаа орхууд, Изенгардын урвалт, тагнуулч шувууд, Хоббитанаар шиншилж яваа хар морьтнууд, далавчит айдас, үхдэл сүгнүүдийн тухай саналаа. Түүний бие салганан чичирч, ямар ч найдвар алга болов. Яг энэ үед нар хар далавчны цаагуур орох мэт бүүдэгрэв. Тэнгэрийн доорхи тэртээ алсаас ямар нэг зэвүүн, бөглүү мөс шиг хүйтэн орилоон сонсогдов. Тэр агзасхийн хананд наалдав.

- Юу болов? Ямар нэг юм мэдрэгдэв үү - гэж Берегонд асуулаа.

- Ти-йм, - бид үхэж байгаа юм шиг санагдлаа. Энэ бол муу ёр, заналт хар морьт тэнгэрт байх шиг санагдлаа.

- Тийм ээ. Муу ёр. Минас-Тирит сүйрэх тавилантай юм шиг байна. Юу ч үзэгдэхгүй харанхуй шөнө болно доо. Миний цус царцчих шиг санагдлаа.

Тэр хоёр уруу царайлан дуугүй хэсэг суулаа. Дараа нь Пин дээш харахад нар урьдын адил гийж, тугнууд салхинд дэрвэн байлаа. Тэр биеэ сэгсрээд:

- Өнгөрөөд явчихлаа, гэхдээ би итгэл найдвараа алдаагүй шүү. Гэндальф үхчих шиг л болсон, гэтэл эргээд ирсэн, бидэнтэй хамт байж байна. Өрөөсөн хөл дээрээ ч гэсэн тэсээд зогсоно, бүр арга барагдвал өвдөг дээрээ тэсээд зогсоно доо! гэв.

- Маш зөв! гэж Берегонд хэлээд босч, хойш урагшаа алхан:

- Үгүй шүү, дайсан ядаж хэзээ нэгэн цагт хумхийн тоос болно, харин Гондор одоохондоо бүрэн бүтнээрээ байна. За яахав, Минас-Тиритийг хэрэмтэй нь чацуу болтол хүүр овоолоод эзэллээ гэж бодоход дахиад өөр цайзууд байна! Нууц замууд, уулын оромжууд байна. Итгэл найдвараа хадгалъя, ой дуртгалаа энд биш юм гэхэд өөр нэг даруухан ногоон нугад хадгалъя.

- Тийм ээ, харин энэ бүхэн яаж ийгээд хурдхан дуусаасай – гээд Пин санаа алдаад - Миний дайчин гэж юу байхав дээ, би дайн тулааны тухай бодохоос ч айдаг, одоо ингээд байлдана гэж бодоход түүнээс доор юм гэж алга. Өнөөдөр чинь яасан ч урт өдөр вэ дээ, өдөр дөнгөж эхэлж байгаа шүү дээ! Бид юугаа хүлээж, хөшчихсөн юм шиг суугаад байгаа билээ, түрүүлж цохилт өгөх хэрэгтэй шүү дээ! Ристанийхан ч гэсэн Гэндальф очоогүй бол хүлээгээд л сууж байх байсан биз.

- Ээ, чи ёстой загатнасан газар маажчихлаа! - хэмээн Берегонд жуумалзаад – Хүлээж бай, хүлээж бай, Фарамир одоохон хүрээд ирнэ. Тэр жинхэнэ эр зоригтон, хэрэв дайчин эртний дуу, домгуудыг нэгд нэггүй мэдэхгүй л бол муу дайчин, эм тахианы элэг доог болсон амьтан гэж манайхан боддог боловч түүн шиг эр зоригтой дайчин жанжин ховор доо. Би Фарамирын тухай ярьж байна! Тийм ээ, Боромир шиг гайхамшигтай цавчигч биш, гэхдээ хоёр Боромирийн дайтай эрс шийдэмгий жанжин. Харин яаж шийдэх вэ? Юу ч гэдэг билээ дээ... тэдний тэр уулнууд руу дайралтай биш! Тийм хүч алга, тэгэхээр дайраад ирэхийг нь хүлээсэн нь дээр. Тэр цагт харъя л даа! – гээд тэр урт илднийхээ бариул дээр алгадав.

Пин түүн рүү анхааралтай харлаа. Өндөр биетэй, эндхийнхэн бүгдээрээ бардам зантай байдаг ёсоор ихэд бардам, нүд нь гялалзаж, цавчилдахсан гэж тэсч ядан байх ажээ. “Би хаана ирчих нь энэ вэ? – гэж Пин өөрөөсөө асуугаад – Мөн лут дайчин болов оо! Гэндальфын хэлснээр – Шатрын хүү юм уу? Тийм ээ хүү, гэхдээ “байрлалаа олоогүй хүү” гэж бодлоо.

Тэр хоёрыг ярилцаж байх хооронд нар голлож, хонхнууд жингэнэн, хэрэмд хөл хөдөлгөөн ихэсч, харуулуудаас бусад нь хоолоо идэхээр явцгаав.

- За явах уу даа? – гээд Берегонд босч: - Одоохондоо бидэнтэй хамт бай. Дараа нь чамайг хааш нь томилохыг бүү мэд, магадгүй, эзэнтний дэргэд ч байлгаж болно. Одоохондоо бидэн дээр ир, хэн дуртайгаа дагуулж ирж болно.

- Би ч ирнэ ээ, харин дагуулж ирэх хэн ч байхгүй. Хамгийн сайн найз маань Ристанид үлдсэн, надад ярилцах, инээж наргих хүн ч алга. Нээрэн та нар дээр ирэх үү? Чи дарга юм чинь намайг дэргэдээ аваач, дээш нь хэлээд үзээч, аан?

- Үгүй ээ, үгүй - гээд Берегонд инээж – Би ямар ч дарга биш, ердөө л цайзын хамгаалалтын гуравдугаар сумангийн цэрэг. Гэхдээ эрхэм Перегрин минь, цайзын хамгаалалтынхан их хүндтэй хүмүүс шүү, хотод төдийгүй хаа сайгүй л биднийг хүндэлдэг.

- Хүндлүүлж л бай, харин одоо намайг буцаагаад хүргээд өг. Хэрэв Гэндальф ирээгүй байвал танай хүндэт зочин би хандсан зүг рүүгээ алхана аа.

Гэндальф ирээгүй байв. Сураг нь ч алга, тэгээд Берегонд Пинийг гуравдугаар сумантай танилцуулахаар дагуулж явлаа. Дайчид Пинийг харах гэж их хүсч байсан тул Берегонд түүнийг арай л гар дээрээ өргөөд явсангүй. Цайзад Митрандирын дагуулын тухай яриа нэгэнт таржээ. Митрандир тэр хоёр эзэнтэй гурвуулхнаа бүтэн цаг ярилцсан, умард газраас жижиг биет ван ирсэн, Гондорт туслахаар таван мянган дайчин дагуулж ирэх гэнэ, Ристанийн морин цэрэг одоохон давхиад ирнэ, дайчин бүр нэг жижиг биетийг сундалж ирнэ, жижиг биет дайчид жижиг гэлтгүй эрэлхэг баатар дайчид гэхчлэн ярьцгааж байв.

Пин найдвар төрүүлсэн тэдгээр цуурхалыг санаа зовон байж няцаасан боловч шинээр олдсон ван хэргэмээс татгалзаж яагаад ч чадсангүй, ван байлгүй яадаг юм бэ – Боромиртой нөхөрлөж явсан, Денэторын ивээлд багтсан. Хүрч ирсэнд нь түүнд талархацгаагаад хэлсэн үг бүрийг нь анхааран сонсч, харийн газар орнуудын тухай шалгааж, пиво, борог хоолоор өгөөмөр дайлцгаав. Пин “болгоомжтой бай” гэсэн Гэндальфын зөвлөгөөг дагах гэж байдгаараа хичээн хоббит зангаараа чалчихгүй гэж их мэрийв.

Эцэст нь Берегонд босч:

- За баяртай нөхөд өө! Би нар жаргатаг харуулын байран дээр зогсоно, та нар ч гэсэн бас л бэлэн байдалд байх ёстой байх – гээд Пинд хандаж харин чи уйдаггүйн тулд хөгжилтэйхэн дагуул олж ав, миний хүү ч байсан болно, тэр ч ёстой нэг баярлана даа! Сайн хүү байгаа юм. Хэрэв зөвшөөрч байгаа бол доод давхарт очоод Дэнлүүчдийн гудамжин дахь Раг-Келердайны хуучин дэн буудалд яаж хүрэх вэ – гэж хүмүүсээс асуу, тэгээд л миний хүүг олоод ав, тэр тэнд үлдсэн хүүхдүүдтэй байгаа. Тэгээд та хоёр Их хаалга руу очихгүй юу, тэнд үзэж харах юм олдоно.

Берегонд явж одоход бусад нь ч тарав. Урьдын адил нартай боловч нэг л хавар цагийн биш хачин утаархаг байв. Мэдээж өмнөд нутаг боловч арай л дэндүү. Пиний нойр хүрч байсан боловч хоосон байрандаа очихыг хүссэнгүй, хотоор зугаалахаар шийдэв. Тэгээд Аянгад бага сага амттан авч очиход тэр цатгалан байсан ч авчирсан юмыг нь голсонгүй идлээ. Пин муруй тахир замаар доош уруудав.

Замд тааралдсан хүн бүр урдаас нь ч нүд бүлтийлгэж, араас нь ч ширтэж байлаа. Бүгдээрээ гондор заншлаар хоёр алгаа зүрхэн дээрээ тавин мэхийж ёслоод, дараа нь: “Харцгаагаарай Митрандирын дагуул, жижиг биетүүдийн орны ван явж байна!” - гэцгээнэ. Нийтийн хэлээр болон өөрсдийнхөө хэлээр нэг л үг хэлээд байгаа нь эндхийн хэлээр түүнийг “Эрнил-и-Ферианнаг” буюу жижиг биет ван хэмээн хүндэтгэн нэрлэж байгааг Пин ойлгов. Энэ нэр түүнд салахааргүй наалдах шиг боллоо.

Тэр хоёр талын нуман хаалганууд, чулуун хавтангаар тавьсан хажуугийн нарийн гудамнууд, тэгшхэн гудамжнуудын тоог алдаж, эцэст нь хамгийн уудам эхний давхарт орж ирэв. Тэнд хүмүүс Их хаалга руу хөтөлсөн Дэнлүүчдийн гудамжийг зааж өглөө. Тэгээд хуучин дэн буудал хэмээх хоёр жигүүртэй саарал чулуун байшинг олов. Багананууд, үүдний өргөн талбайтай, олон цонхтой тэр байшингийн урд талд нарийхан зүлэг байна. Багануудын хоорондуур хүүхдүүд тоглож байлаа, Пин тэднийг ажиглаж жаахан зогсов. Минас-Тиритэд ирсээр тэр хүүхэд хараагүй билээ. Удалгүй тэдний нэг нь Пинийг анзаараад хашгиран шатаар гүйж, зүлгэн дээгүүр жирийгээд Пиний өмнө ирэхэд бусад нь даган гүйж ирэв. Түрүүчийн хүү Пинийг харцаараа хэмжиж зогсонгоо:

- Сайн уу! Чи хаанаас ирсэн юм бэ? Эндхийнх биш юм шиг байна даа

- Ер нь бол эндхийнх биш ээ, гэхдээ одоо гондорын дайчин.

- Чиний дайчин ч гайгүй байна аа! – гэж хөвгүүн инээгээд - Чи дайчин бол энд байгаа хүүхдүүд бид бүгдээрээ дайчин. Чи хэдэн настай вэ, нэрийг чинь хэн гэдэг вэ? Би арван настай, удахгүй би арван фут өндөр болно. Одоо ч гэсэн би чамаас өндөр байна. Миний аав хэрмийн харуул, тэд нарын хамгийн өндөр нь. Чиний аав хэн бэ?

- Чиний аль асуултанд эхэлж хариулах вэ? - гэж Пин хариу асуугаад – Миний аав бол Хоббитани Молтогчингуудын Цагаан суурины ногоочин. Би удахгүй хорин ес хүрнэ. Энэ талаар би чамаас түрүүлж явна. Би дөрвөн фут өндөр, нэмж өндөр болохгүй, өргөөшөө л томрох байх.

- Хорин ес гэнэ ээ! – гээд хөвгүүн исгэрч: - Чи чинь манай Иорлас ах шиг хөгшин юм байна шүү дээ. Гэлээ ч гэсэн хамаагүй, би хүсэх юм бол чамайг хөлөөр чинь тэнгэр харуулсан ч чадна, далаар чинь тавьсан ч чадна – гэж цоглог хэлэв.

- Харуулж ч магадгүй, тавьж ч магадгүй – хэмээн Пин инээгээд – хэрвээ намайг хүсвэл шүү дээ. Магадгүй би чамайг харуулж, тавьж ч болно, манай нутгийнхан бас зодоонд муугүй. Манай нутагт би хамгийн том, хамгийн хүчтэй нь байсан болохоор хэн ч намайг толгойгоор минь тонгорцоглуулж, далаар минь тавих гэж оролдоогүй. Хэрэв чи гэнэт оролдоод үзвэл одоо яая гэхэв, би чамайг шоглох болно. Том хүн болоод хүнийг гадаад байдлаар нь үнэлэхээ болино биз. Би чамд үлээхэд л хийсээд явчихмаар хариугүй бяцхан амьтан харагдсан байлгүй, үнэн хэрэгтээ бол би хүний цусанд шунасан, аймшигтай, хүчирхэг одой хүн шүү дээ! - гээд Пин царайгаа аймаар хачин болгоход хөвгүүн гэдрэг ухарсан боловч тэр дороо нударгаа зангидан, нүд нь гялалзсаар ойртов.

- Өө за за! - хэмээн Пин инээж: - Танихгүй мэдэхгүй хүний үгийг үнэмшиж болохгүй, таньж

мэдэхгүй харийн хүн өөрийнхөө тухай юу ч гэж худлаа ярьж болно! Би тийм аймаар амьтан биш, харин чи хэдэрлэхийн оронд эхлээд нэрээ хэлвэл яасан юм бэ, хүмүүстэй соёлтой харилцах хэрэгтэй.

Хөвгүүн бардмаар эгцхэн зогсоод:

- Би бол Бергил, цайзын хамгаалагч Берегондын хүү.

- Харваас тийм байна, - гэж Пин толгой дохиод, - Чи аавтайгаа дэндүү адилхан юм. Би аавтай чинь хамт явж байгаад ирлээ.

- Тэгвэл түрүүний хэлэхгүй яасан юм бэ? – гээд Бергил гэнэт уруу царайлж: - Охидуудтай явуулах гэж аав шийдсэн юм биш биз дээ? Арай үгүй байлгүй, сүүлчийн цуваа явчихсан шүү дээ!

- Айхаа азна, бүх юм тийм ч аймшигтай биш байна, одоохондоо аав чинь чамд намайг толгойгоор нь тонгорцоглуул гэж тушаагаагүй, харин надтай хамт явж хотоо үзүүл гэсэн. Хариуд нь би чамд харийн улс орнуудын тухай ярьж өгнө.

Бергил ихэд баярлан алгаа ташив:

- Тэгвэл бүх юм сайхан, ура! - хэмээн хашгираад: - Тэгвэл явцгаая! Бид яг Их хаалга руу явах гэж байсан юм, тийшээ гүйе!

- Гүйж яах юм бэ?

- Өнөөдөр нар орохоос өмнө холбоотны дайчид ирэх ёстой! Явъя, явъя, өөрөө очоод үзээрэй.

Бергил үнэхээр сайн найз байлаа. Пин Мерриггүйгээр тун их ганцаардаж байсан юм. Тэр хоёр дорхноо сайн андууд болж, ам хуурайгүй ярьж, алиа хошин үг солилцож, гудамжаар гар гараасаа хөтлөлцөн алхах бөгөөд тал талаас нь сониучирхан харж буй хүмүүсийг ч анзааралгүй явлаа. Хүмүүс их хаалган дээр бөөн бөөнөөрөө ирж байсан бөгөөд Пин нэрээ хэлж, нэвтрэх үнэмлэхээ үзүүлэхэд харуулууд тэр хоёрыг хамтад нь нэвтрүүлэхэд Бергил маш баяртай байв.

- Ёстой гоё! Биднийг том хүнгүйгээр гадагш гаргадаггүй юм. Одоо ч ёстой харж өгнө дөө!

Хүмүүс Минас-Тирит руу ирсэн бүх замын уулзвар болсон чулуун тавцант талбай дээр бөөгнөрч байлаа. Бүгдээрээ л өмнө зүг рүү харж байсан бөгөөд тун ч удалгүй:

- Тоос, зам дээр тоос гарч байна! Тэд ирж явна! – гэгцгээв.

Пин, Бергил хоёр хүмүүсийн дундуур зүтгэсээр урд эгнээнд гарч амжив. Холгүйхэн эвэр бүрээ цангинахад угтуул салхи адил хариу дуу хүнгэнэлээ. Дараа нь яндан хүнгэнэж, хүмүүс нэгэн дуугаар:

- Форлонг! Форлонг! – хэмэн цуурайтуулав.

- Форлонг гэж юу юм бэ? – гэж Пин асуухад Бергил:

- Яагаав Форлонг л байхгүй юу, Лоссарнахын жанжин Брюхан Форлонг! Тэнд миний өвөө амьдардаг юм, Ура! Бидний хамгийн сайн анд, өвгөн Форлонг өөрөө ирлээ! – гэж хашгирав.

Дайчдын цувааны манлайд хүчирхэг том морь унасан, өргөн цээжтэй өндөр чацархаг биетэй буурал сахалтай, асар урт жад барьж, өвч битүү хөө хуяг өмссөн өвгөн дайчин явж байна. Түүний араас Минас-Тиритийнхнээс арай намхан, бараан царайтай хүдэр чийрэг биет дайчид хоёр эгнээгээр орж ирэв. Тэдний царай ширүүн догшин, мөрөн дээрээ урт урт жадаа ярайлган явна.

- Форлонг! Үнэнч анд, баатар ван! Ура, Форлонг! – хэмээн хүмүүс нижигнэтэл хурайлав.

Гэвч Лоссарнахын дайчид их хаалгаар орсны дараа хүмүүс:

- Ямар цөөхөн юм бэ, ердөө л хоёрхон зуут байна! Бид хоёр мянган дайчин ирнэ гэж найдаж байсан шүү дээ. Дайсан тэднийх рүү довтолсон учир арван дайчны ес нь хотоо хамгаалахаар үлджээ. За яахав, ганц дайчин ч ганцаардахгүй – гэцгээв.

Их хаалганд хүмүүсийн баяр хүргэсэн түрхрэн дунд холбоотны дайчид ар араасаа ирсээр байв. Гондорын хязгааруудаас нийслэлээ хамгаалуулахаар дайчдаа илгээжээ. Гэвч бүгд эндхийнхний хүлээж байснаас цөөн дайчин илгээжээ. Ринглогийн хөндийгөөс тэндхийн жанжин захирагч Дерворин тэргүүтэй гурван зуун дайчин иржээ. Мортхондын уулсаас өндөр чилгэр Дуингир өөрөөс нь ялгарахааргүй хоёр сайхан хүү Дуилин, Деруфин хоёртойгоо таван зуун харваач дагуулан иржээ. Алсын Анфаласын хязгаараас анчин, малчин, суурингийнхны урт цуваа аль тааралдсанаараа зэвсэглэн ирсэн ба тэдний захирагч Голасгил л өөрийн хэдэн дайчинтайгаа байлдааны зэвсэг агссан байна. Ламедонаас хэдэн арван дүнсгэр царайт дайчин ирлээ. Андуины нэг салаа Этхир мөрнөөс зуу гаруй загасчин дажгүй зэвсэгтэй ирж, бусад нь хөлөг онгоцон дээрээ үлджээ. Үзмэн толгодын цагаан толгойт Гирлуин жанжин жинхэнэ дайчны ёсоор хувцаслаж, зэвсэглэсэн гурван зуун дайчин удирдаж иржээ. Эцэст нь Дол-Амротын эзэн захирагчийн хүү Имраиль хөлөг онгоц, мөнгөн хунгийн дүрст далбаагаа дэрвүүлэн тэргүүн морьт хорооныхоо манлайд хатируулан орж ирэхэд араас нь булиа чийрэг хар үст, саарал нүдэт долоон зуун дайчид дайчин тугийнхаа сүлд дууллыг дуулан орж ирлээ.

Ингээд ердөө л гурван мянган дайчин ирэв. Өөр хүлээгээд байх хэн ч байсангүй. Их хаалганы дэргэдэх талбайд уриа цуурай, дуу шуу намжлаа. Цугларсан хүмүүс хэн нэгнийг хүлээх мэт тарж ядан байв. Агаарт дайчдын цувааны тоос манарч, бүгчимхэн болов. Орой болж, хүрэн улаан нар Миндоллуины цаагуур оров. Гондорын нийслэл үдшийн бүрэнхийд умбалаа.

Пин дээшээ харахад тэнгэр тоосон цаанаас мэдэгдэх төдий хөхвөртөж, үдшийн саарал гэгээ тоосон үүлийг арай ядан нэвтэлж байлаа. Зөвхөн баруун зүгт л улаан туяа татаж, Миндоллуины хар бараан өнгөт нүсэр биеийн энд тэнд нүүрсний цог улалзах мэт харагдана.

- Энэ өдөр мөн ч тунгалаг эхэлсэн юмсан, мөн ч будангуй дуусч байна даа – гэж Пин дэргэдээ байгаа хөвгүүнийг мартчихаад өөртөө бувтнатал:

- Дохионы хонх дуугарахаас өмнө орохгүй бол бүр ч будангуй дуусна, түргэлээрэй, одоохон орохгүй бол хаалга хаагдана - гэж Бергил яаруулав.

Тэр хоёр хотод хамгийн сүүлд эргэж ирэв. Хаалга тэр хоёрыг оронгуут хаагдаж, Дэнлүүчдийн гудамжаар алхаж явахад цамхгийн хонхнууд дуу дуугаа авалцан цууриалж байлаа. Цонхнууд гэрэлтэн, хэрмийн хананы дэргэдэх хуарангийн байшингуудаас дайчдын дуулах сонсдоно.

- За за, би явлаа, аавд мэнд хүргээрэй. Сайн андтай болгосонд баярлалаа гэж дамжуулаарай. Чи маргааш эртхэн ирээрэй. Дайн болохгүй бол сайхан аа, бид дайнгүйгээр амьдарч болно шүү дээ. Лоссарнахд байгаа өвөөгийндөө очоод л, тэнд хавар ёстой гоё байдаг, ойд ч, талд ч дүүрэн цэцэг алаглаад л. Ерөөсөө шууд л яваад очъё. Тэр муу дайснууд манай эзэн захирагчийг дийлнэ гэж юу байдаг юм бэ. Миний аав ганцаараа тэдний толгойг бүгдийг нь тас цавчина. Маргааш эрт ирээрэй! Тэр хоёр салж, Пин байр руугаа яарав. Нэлээд алхсан тул хөлөрч, бас өлсөв. Бүгчим харанхуй шөнө боллоо. Оройн хоолноос хожимдсон нь мэдээж боловч түүнд хоол үлдээжээ. Берегонд түүнийг орж ирэхэд их баярлаж, хүүгийнхээ тухай баахан шалгаав. Идэж цадаад бага зэрэг амраад бүгдэд Пин сайхан нойрсохыг ерөөв. Тэр их ядарч, бас Гэндальфыг хурдхан харахыг хүсч байлаа.

- Чи ганцаараа явж чадах уу? – гэж Берегонд, өдөр хоёулаа сууж байсан сандлын дэргэд хүртэл дагаж яваад асууснаа - ёстой жинхэнэ харанхуй шөнө байна, гэвч бүх гэрлийг унтраах тушаал өгсөн. Чамайг өглөө эрт эзэн захирагч Денэтор дээр орж ир гэж тушаасан. Чамайг манай гуравдугаар суманд өгөхгүй л болов уу дээ. За яахав, харж байж л больё. Баяртай сайхан нойрсоорой!

Байранд харанхуй, ширээн дээр дэнлүү асаастай байна. Гэндальф ирээгүй байсан учир Пинд их л уйтгартай байлаа. Тэр сандал дээр гараад цонхоор харахад юу ч харагдаагүй учир сандлаас бууж, цонхны хөшгийг татав. Тэгээд орондоо орж, Гэндальфыг орж ирэхийг хэсэг хүлээж хэвтсэнээ тэгсгээд унтчихжээ.

Шөнө дунд гэрэл асахад тэр сэрэв. Гэндальф орж ирээд өрөөн дотуур хойш урагш алхахад түүний сүүдэр цонхны хөшгөн дээр сүүтэгнэж байв. Ширээн дээр дэнлүү асаастай, дэргэд нь боодолтой юмнууд байна. Шидтэн санаа алдаж:

- Фарамир яагаад одоо болтол алга байна? – гэж бувтнахыг нь сонсоод Пин:

- Өө-хөөе! – хэмээн хөнжлөө сөхөж: - Чи намайг мартчихсан юм байх л гэж бодлоо. Эргэж ирсэнд чинь баярлалаа. Мөн ч урт өдөр байлаа шүү - гэв.

- Гэвч богинохон шөнө болно оо. Би алдаа гаргахгүй сэтгэх гэж л орж ирлээ. Харин чи унтаж ав. Дахиад хөнжилд орж унтаа ч уу, үгүй ч үү. Үүрээр хоёулаа Денэтор дээр орно. Үүрээр ч гэж дээ, дуудахаар нь л орно. Их харанхуй нэгэнт эхэлчихсэн, үүр цайхгүй.

Бүлэг 2

Саарал бүлгийн аян

Гэндальф давхин одоход Аяндын туурайн төвөргөөн харанхуй шөнийн агаарт уусан сонсдохоо болив. Мерри жижигхэн боодолтой юм барьсаар Арагорн руу гүйж ирэв. Түүний үүргэвч Парт-Галенд үлдсэн учир тэр зам зуур хэрэглэх юмаа Изенгардын нуранги дотроос түүж авчээ. Хазуфелийг аль хэдийн эмээллэж, Леголас, Гимли хоёр мориныхоо дэргэд зогсч байлаа.

- Манай отрядаас дөрвөн хүн үлджээ. За яахав дөрвүүлээ бол дөрвүүлээ л биз, гэхдээ яг ч дөрвүүлхнээ биш ээ, захирагчтайгаа хамт. Тэр одоо гарч ирж байгаа. Далавчит сүүдэр түүнийг болгоомжлуулсан учир тэр үүр цайтал ууланд нуугдахаар шийдсэн байна – гэж Арагорн хэлэв.

- Ууланд ч нуугддаг л юм байж, харин дараа нь яах гэж байгаа юм бол? – гэж Леголас асуув.

- Дараа нь яахыг мэдэхгүй, - хэмээн Арагорн бодлогошронгуй хариулаад – Захирагч Эдорас руу явна, тэнд тэр дөрөв хоногийн дараа дайчдын цугларалт зарласан юм. Тэнд тэр таагүй мэдээ дуулах байх аа, тэндээс ристаничууд Минас-Тирит руу хөдлөх гэж байгаа. Би тэдний тухай яриагүй байна, өөрийнхөө тухай болон намайг дагаж яваа нөхдийн тухай л ярьж байна...

- Би чамтай хамт явна! - гэж Леголас хэлэв.

- Би ч гэсэн хоцрохгүй! - гэж Гимли зэрэг шахам хэлэв.

- Үгүй дээ, бүх юм тийм амархан биш байна, миний нүдийг манан хаагаад байна. Би Минас-Тирит явах хэрэгтэй юм шиг байх юм, гэхдээ таньж мэдэхгүй өөр замаар явах ёстой юм шиг байна. Яван байж л мэдэхээс дээ – гэж Арагорн хэлэв.

- Та намайг аваад яваарай даа! - гэж Мерри гуйгаад: - Одоохондоо миний хэрэг хэнд ч байхгүй гэдгийг ойлгож байна л даа, гэхдээ л намайг хэрэггүй юм хэрэггүй гээд хаячихаж болохгүй биз дээ! Захирагч хоолны ширээнд намайг хажуудаа суулгаж, Хоббитаний тухай яриулна гэж амласан боловч Ристанийн морьт дайчдад би ямар ч хэрэг байхгүй – гэхэд Арагорн:

- Тийм ээ Мерри, чи тэдэнтэй л зам нийлэх байх, харин үдэлж амрах, үдийн хоол идэх найдвар байхгүй шүү. Теоден Медусельддээ хаан ширээнд мөд суухгүй гэж айж байна даа! Энэ бэрх хавар олон мөрөөдөл биелэхгүй шүү.

Төдөлгүй хорин дөрвөн морьтон шөнийн харанхуй дундуур давхин одов. Гимли Леголасын араар сундалж, Меррийг Арагорн дүүрчээ. Тэд дөнгөж Изений гарам хүрмэгц арын морьтонгуудын элч гүйцэж ирээд:

- Эзэн минь, бидний араас хөөж байна. Бид голд дөхөж явахад л би араас хөөж байна гэж мэдсэн. Одоо бол ямар ч эргэлзээ алга. биднийг гүйцэж байна, тэд хамаг байдаг хурдаараа давхиж байна – гэж захирагчид хэлэв.

Теоден зогсох тушаал өгөхөд морьт дайчид жолоогоо эргүүлэн зогсч илд жадаа бэлтгэв. Арагорн яаран Мерриг газар буулгаж хэвгүүлээд илдээ сугалан захирагчийн дэргэд зогслоо. Эомер ард хоцорч яваа дайчдыг авчрахаар хамгаалагчтайгаа эргэж давхилаа. Мерри “Би ч ёстой хэнд хэрэггүй ачаа л юм даа, одоо ингээд эд нар маань дайснуудтай цавчилдаж эхэлнэ, тэгэхэд би юу хийх вэ? Энэ хэдхэн дайчдыг тэр үй олон дайсан бүгдийг нь хүйс тэмтэрнэ, би харанхуйгаар яаж ийгээд үзэгдэлгүй амьд гарлаа гэж бодоход дараа нь Ристанийн онгон зэлүүд, зах хязгааргүй талд ганцаараа юу хийх болж байна? “Үгүй шүү” гэж тэр өөртөө хэлээд, илдээ сугалж, бүсээ чангалав.

Сарны наагуур асар том хар үүл бүрхсэн боловч, сар гэнэтхэн тэр үүлнээс гараад ирэв. Тэгтэл морин төвөргөөн тачигнаж, гармын тэндээс хар морьтонгуудын дүрс тодрон ойртлоо. Сарны гэрэл жаднуудын үзүүрээс ойж харагдав. Хичнээн дайсан байгаа нь одоохондоо тодорхойгүй боловч ямар ч гэсэн биднээс олон юм байна гэдгийг хүн бүр мэдэж байлаа.

Тэд тавиад алхам ойртон ирэхэд Эомер:

- Зогс! Хэн Ристанд ийм аймшиггүй явж байна? – гэж хашгиран асуув.

Морьтнууд хоромхон зуурт шаасан гадас мэт нам зогслоо. Нам гүмийн дундаас нэг морьтон аажуухан урагшлан дөхөж ирэв. Тэр эв найрамдлын бэлэг тэмдэг болгож гараа өргөхөд сарны туяанд алга нь цайран үзэгдэв. Гэлээ ч гэсэн ристани дайчид илд, жадаа бэлэн байлгав. Тэднээс арваад алхмын зайд газраас ургаад гараад ирсэн юм шиг өндөр бараан морьтон зогсч, эр хонгор дуугаар:

- Ристанид гэв үү? Чи Ристанид гэж хэлсэн үү? Бид энэ үгийг сонсоход их баяртай байна. Бид алс холоос Ристани руу яаран давхиж ирсэн юм – гэлээ..

- Тэгвэл одоо та нар хаашаа ч яарах хэрэггүй болжээ, гамраар гарсан л бол та нар Ристанийн газар нутагт байна. Энэ орныг эзэн ван Теоден захирдаг, тиймээс энэ оронд зөвхөн түүний зөвшөөрлөөр л зорчиж болно. Та нар хэн бэ? Ямар хэрэг зоригоор яарч давхина вэ? – гэж Эомер асуув.

- Би умардын мөрч Гальбарад Дунадан байна, бид Араторны хүү Арагорныг зорьж явна. Тэр Ристанид яваа гэж бид сонссон юм.

- Та нар зорьсон хүн дээрээ ирчихээд байна! - гэж Арагорн дуу алдав. Тэр урагш гүйн гарч, ирсэн дайчинтай тэврэлдэн уулзав.

- Энэ чинь чи мөн гэж үү, Гальбарад! Ёстой санамсаргүй их баяр гэж энийг л хэлнэ дээ!

Мерри санаа амарч сайхан гэгч санаа алдав. Бүрэн бут цохигдоогүй Саруман Ристанийн эзэн ванг дагуулуудтай нь устгахаар ирсэн гэдэгт тэр эргэлзэхгүй байсан бөгөөд одоо Теоденыг

хамгаалан толгойгоо тавьж өгөх хэрэггүй боллоо, хэрэгтэй бол дараа л болно биз гэж бодоод илдээ хуйлав.

- Бүх зүйл хэвийн байна, - Эд нар бол миний төрөл садангууд, миний олон жил амьдарч байсан алс хязгаараас энд хүрч иржээ гээд ирэгсдийн тэргүүнд хандан

- Гальбарад яагаад наашаа давхиж ирсэн бэ, хэдүүлээ яваа вэ гэдгээ бидэнд хэлж өгнө үү? - гэж Арагорн хэлэв.

- Бид гучуулаа, дуудлага өгч амжсан хүн бүр ирсэн, ах дүү Элладан, Элроир хоёр ч ирсэн. Эд нар маань бидэнтэй хамт тулалдана. Бид чиний дуудлагыг хүлээж авангуут наашаа хөдөлсөн.

- Дуудлага аа? – Би та нарыг зөвхөн дотор санаандаа л дуудсан шүү дээ. Та нарын тухай байн байн бодож байсан, одоо бол урьдынхаасаа олон удаа бодож байна. Гэхдээ дуудлага өгч амжаагүй. За энэ бүгдийг дараа л ярья. Бид аюултай тулгараад байна, алгуурлаж хэрхэвч болохгүй. Эзэн ван зөвшөөрвөл хамтдаа давхицгаая.

- Яг цагаа олж ирлээ та нар! – хэмээн баярласан Теоден хэлээд: - Хэрэв чиний садан төрлүүд чиний дайтай бол гучин ийм баатар дайчин бүхэл бүтэн арми гэсэн үг, эзэн хаан Арагорн минь!

Тэд цааш давхилдав. Арагорн дунаданчуудтай зэрэгцэн давхиж, умард, өмнөд газрын сонин солилцлоо. Элроир Арагорнд хэлэв:

- Аав чамд ингэж хэлүүлсэн. Цаг мөч бүхэн алтнаас үнэтэй байна. Хэрэв хожимдох юм бол үхдлүүдийн замыг санаарай! – гэсэн шүү.

- Миний хувьд цаг, мөч, хором бүхэн тооцоотой байдаг, цаг, мөч, хором бүхэн ямагт дутагдаж байдаг. Гэвч энэ замаар явахын тулд надад хожимдох аюул маш их байдаг.

- Юу л гэж шийднэ, түүгээрээ бол. Харанхуй шөнө аяны зам дээр энэ талаар яриад яахав.

- Чи юу авч яваа юм бэ, дүү минь? – гэж Арагорн Гальбарадаас асуув. Учир нь түүний гарт жад биш, тугны иш шиг урт саваа байх бөгөөд бараан бөсөөр чангалан ороож, сураар боосон байхыг Арагорн харжээ.

- Энэнийг Уудам хөндийн эзэгтэй чамд илгээсэн юм. Тэр үүнийг аль эртнээс нууцаар хийж байсан юм. Тэгээд чамд ингэж хэлүүлсэн. Цаг мөч бүхэн алтнаас үнэтэй байна. Нэг бол бидний мөрөөдөл биелнэ, нэг бол хамаг итгэл найдвар маань эцэс болно. Би бүгдийг өөрийнхөө төлөвлөснөөр хугацаанд нь хийж дуусгалаа. Сайхан цаг иртэл түр баяртай, Эльфийн сувд эрдэнэ минь! Ингэж л хэлүүлсэн дээ.

Арагорн хариуд нь:

- Тэгвэл чи юу авч ирснийг би мэдлээ. Миний төлөө наадахаа дахиад жаахан хадгал даа! – гэв.

Тэр умар зүг рүү эргэж, том том хурц тод одод руу нэг хараад шөнийн турш давхихдаа дахиж нэг ч үг хэлсэнгүй.

Үүрийн өмнөх харанхуй тэнгэрийн доор тэд хавцлын хонхроос гарч Горнбург хүрэв. Бага зэрэг морь, биеэ амраагаад цаашид яах тухайгаа хэлэлцэх хэрэгтэй байлаа.

Мерри тарвага шиг нам унтаж байтал Леголас, Гимли хоёр түүнийг сэрээв.

- Тэнгэрт нар мандлаа – гэж Леголас хэлээд – Бүгд босчихоод байхад ганц чи л ногоортлоо унтаад байх юм. Бос, тэгэхгүй бол малгайн цуглаанаас хоцрох нь байна!

- Гурав хоногийн өмнө энд аймшигтай тулалдаан болсон юм. Би Леголаст хариугүй хожигдохоо шахаж байж арай л хожигдчихолгүй нэг орхийг түүнээс илүү алсан шүү! Явцгаая, хаана тулалдаан болсныг үзүүлье! Тийм ээ, Мерри, энд ямар агуйнууд байдаг гэж бодно! Агуйнуудаар орж үзье, тэгэх үү, Леголас?

- Үгүй ээ, хэрэггүй, хэрэггүй, - гэж эльф дайчин хэлээд – Хэн ийм яаруу давчуу цагт элдэв юм сонирхож байлаа даа! Бид хоёр энэ бэрх цагийг амьд туулаад гардаг юм бол тийшээ хамт явна гэж тохиролцоо биз дээ. Одоо бараг үд болох гэж байна, хоолоо идээд замдаа гарна.

Мерри амаа байдгаараа ангайн эвшээж, нэг сайн суниаж авлаа. Сайхан унтсан ч гэсэн ядаргаа нь гарсангүй, урьдахаасаа ч илүү гунигтай байв. Пин байхгүй болохоор чөлөөтэй ярилцах хэн ч байдаггүй, эргэн тойронд бүгдээрээ л яарч, тэр л ганцаараа тэнэг царайлж яваа билээ.

- Ядаж Арагорн хааччихав аа? – гэж тэр асуувал:

- Дээр, цамхаг дээр байгаа, - хэмээн Леголас хариулаад: - Амарсан ч юм байхгүй, бүр нүдний хор ч гаргаагүй. Тэр их юм бодох хэрэгтэй. Гальбарад бас түүнтэй хамт байгаа. Түүний санаа бодол хэцүү байх шиг байна. Бүдэг бадаг эргэлзээ, санаа зовоох юм их байна.

- Эд нар угаасаа баргар царайтай хүмүүс, үнэхээр шилж сонгож цуглуулсан юм шиг хүчирхэг, чацархаг баатар вангууд, ристанийхан эдний дэргэд хүүхэд л гэсэн үг, нар салхинд онгож гандаж ширүүн бараан царайтай болсон улс, яг л Арагорн, эднээс илүү ганц үг сонсоно гэж гоньж – хэмээн Гимли үглэв.

- Арагорнтай адилхан гэж чи үнэн хэллээ шүү - гэж Леголас батлаад – Яг тийм дуу цөөтэй, нэг үг хэлбэл яг л түүн шиг жинтэй үг хэлнэ. Тэр нөгөө ах дүү хоёр Эллада, Элроир хоёр? Энэ хоёрын хувцас нь гоё ганган, зүгээр нэг хүний хүүхдүүд биш, Уудам хөндийн эзэн Элрондын хүү шүү дээ!

- Эд нар яагаад гэнэт давхиад ирэв, чи мэдэж байна уу? - гэж Мерри асуув. Тэр хувцаслаж, саарал цуваа мөрөндөө углаад гурвуулаа нурсан цайзын хаалган дээр гарч ирэв.

- Эднийг дуудсан гэсэн, тэгээд л хүрээд ирэхгүй юу, би энэ хоёр чихээрээ сонссон – гэж Гимли хариулаад: - Уудам хөндийд нэг дуу хоолой сонсогдсон гэнэ. Арагорн ах дүү нараа

хүлээж байна, Дунаданчууд аа, Ристан руу яараарай! гэж. Хэн эднийг тэгж дуудсан бэ гэвэл мэдээж Гэндалф, өөр хэн байхав дээ.

- Үгүй ээ, Гэндалф биш, Галадриэль хэмээн Леголас өгүүлээд: - тэр л Гэндалфын амаар Саарал бүлгийг дуудсан байна биш үү?

- Тийм ээ, чи оноод хэлчихлээ - гэж Гимли зөвшөөрөв: - Гайхамшигт ойн орны эзэн тэр л дуудсан байж таарна! Хэн бусдын зүрх сэтгэлийг уншиж, нандин мөрөөдлийг нь биелүүлдэг билээ дээ! Харин чи бид хоёр ч тэнэг юм даа Леголас, яагаад бид хоёр өөрсдийнхнийгөө дуудаагүй билээ?

Леголас хаалганы дэргэд зогсоод, хурц нүдээрээ хойт болон зүүн зүг рүү харахад царай нь барайв.

- Манайхан ирэхгүй, өөрсдийнх нь босгон дээр дайн тулж ирчихээд байхад хаа байсан газар руу юундаа яарах билээ?

Тэр гурав дахиад жаахан алхаж, саяхан болсон тулалдааны тухай ярилцаад, дараа нь нурсан хаалгаар гадагш гарч, замын хажуу дахь шинэхэн булшнуудын хажуугаар өнгөрөн өндөрлөг дээр гараад хонхор руу харав. Үхмэл уул өмнө нь харлан сүндэрлэж, эргэн тойронд нь өвс ургамлыг дэвсэлж, газрын хөрсийг зурсан гворнуудын мөр харагдана. Дунадандчууд болон Горнбургийн хамгаалагчид цайзыг сэргээн барьж, талбайг тэгшлэн, ханыг шинээр босгож, далан овоолж байсан ч эргэн тойронд нэг л хачин тайван, хөндий тал дайрч өнгөрсөн шуурганы дараа амарч байгаа юм шиг байв. Тэр гурав өдрийн хоолноос хоцрохгүйн тулд эргэж ирлээ.

Эзэнтэн тэднийг хараад Мерриг дуудаж, дэргэдээ суулгав.

- Энд алтан ганжирт Эдорасын цайз шиг тав тухтай биш нь мэдээж, чиний найз ч энд алга, байсан бол аятайхан л байх байлаа. Гэвч бид Медусельдийн өндөр ширээний ард дахиад суутал бас өдий байна. Хэрэв тэнд яваад хүрчих юм бол бидэнд найр хийх цаг олдохгүй байх гэж айж байна. Гэвч урьдаас таах гээд яахав! Сайн идэж ууж ав, далимд нь сайхан ярилцъя. Тэгээд надтай хамт яваарай.

- Би тантай хамт явах гэж үү? - хэмээн Мерри бахдан баярлаж – мөн сайхан аа! – Даанч би та нарын хөлд тээглэхээс өөр ямар ч хэрэг байхгүй юм гэж үү?

- Хэрэг болно оо - гэж Теоден батлаад - чамд нутгийн үүлдрийн маш сайн пони морь бэлдсэн. Уулын замд яг тийм л морь хэрэгтэй, хоцорно гэж байхгүй. Бид Эдорас руу уулаар явна, Дунхергийн даваагаар, тэнд намайг Эовин хүлээж байгаа. Миний зэвсэг хадгалагч болохыг хүсч байна уу? Эомер, энэнд зэр зэвсэг, хөө хуяг олдох уу?

- Зэр зэвсэгээр ч маруухан байгаа шүү, эзэн минь, хөнгөн дуулга олдоно, харин таарах хөө хуяг, илд олдохгүй л байх даа - Эомер хариулав.

- Надад илд байгаа - гээд Мерри босон харайж, гялалзсан илдээ хар хуйнаас нь сугалж

харуулав.

Өвгөн эзний ивээлд биширсэн тэрбээр өвдөг дээрээ сөхрөн гарыг нь үнсээд:

- Эзэн хаан Теоден, Хоббитани Мериадок чамд үнэнчээр зүтгэхээ андгайлахыг зөвшөөрнө үү! Би илдээ өвдөг дээр чинь тавьж болох уу?

- Баяртайгаар зөвшөөрч байна - гээд Теоден хоббитын хүрэн үст толгой дээр урт хуруутай гараа тавьж: - Бос, Мериадок, - одооноос эхлээд чи миний зэвсэг хадгалагч бөгөөд Медусельдын хамгаалагч боллоо. Илдээ зүү, тэгээд Ристани төлөө үнэнчээр зүтгээрэй!

- Одоо та миний эцгийн оронд эцэг минь боллоо - гэж Мерри хэлэхэд:

- Удаан болохгүй байх гэж айж байна, - гэж Теоден хариулав.

Хоолны үеэр ердийн ярилцаж байгаад эцэст нь Эомер хэлэв:

- Одоо явах цаг боллоо, эзэн минь. Бүрээ үлээхийг зөвшөөрнө үү? Ингэхэд Арагорн хаана байна аа? Тэр хоолонд ч ирсэнгүй шүү дээ.

- Хөдлөхөд бэлтгэ, цаг дуусч байна гэж Арагорнд дамжуул - гэж Теоден тушаав.

Эзэн Меррийг дагуулан хамгаалагчидаараа хүрээлүүлэн Горнбургийн хаалгаар гарч ирэхэд уудам нугад дайчид мориндоо мордон жагссан байв. Эзэн цайзад ганцхан жижиг гарнизон үлдээгээд бусад дайчдыг бүгдийг нь Эдорас руу, цэргийн цугларалт руу авч яваа билээ. Урд шөнө мянган дайчин мордсон бөгөөд одоо эзний голдуу вэстфольдчуудаас бүрдсэн таван зуун дайчин мордож байлаа.

Тэднээс зайдуухан үг дуу цөөтэй мөрчид жад, нум сум, илдээ агсан, бүдэг саарал цуваа өмсч, дуулга болон нүүрээ юүдэнгээ буулган халхалж зогсоно. Тэдний морьд хүчирхэг өндөр биетэй, сахлаг үстэй бөгөөд умард нутгаас авчирсан Арагорны Рогерин нэрт морь эзэнгүй зогч байгаа харагдав. Тэдний зэр зэвсэг, эмээл хазаарт ямар ч алт эрдэнэсийн чимэггүй, сүлд тэмдэг ч байхгүй, зөвхөн дайчин бүрийн зүүн мөрөн дээр цувны мөнгөн товч гэрэлтэж байв.

Эзэн өөрийнхөө цагаан дэлтийг унаж, Мерри түүний дэргэд зогсч байсан Стибба нэрт пони дээрээ мордов. Төдөлгүй Эомер, Арагорн, Гальбарад гурав хаалгаар гарч ирлээ. Гальбарад хар бөсөөр ороосон урт саваа барьж, араас нь хөгшин залуу нь үл мэдэгдэх ах, дүү хоёр гарч ирэв. Элрондын хоёр хүү хоорондоо яагаад ч ялгах аргагүй адилхан. Хоёулаа хар үстэй, саарал нүдтэй, эльфийн гэрэл цацруулсан үзэсгэлэн төгс, хоёулаа гялалзсан мөнгөлөг цув, хөө хуягтай. Тэдний араас Леголас, Гимли хоёр гарч ирэв. Гэвч Мерри баргар царайлсан Арагорны ядрангуй царайнаас нүдээ салгаж чадсангүй. Тэр ганц шөнийн дотор олон насаар хөгширсөн мэт харагдав.

- Эзэн минь, миний сэтгэл их түгшүүртэй байна – гэж тэр эзний дөрөөний дэргэд зогсоод – надад муу мэдээ ирлээ. Бидэнд огт мэдээгүй байсан шинэ аюул тулгарлаа. Би удаан бодсоны эцэст төлөвлөгөөгөө өөрчлөх хэрэгтэй гэж шийдэв. Теоден:

- Чи Дунхерг рүү хөдөлж байгаа шүү дээ, тэр хүртэл хичнээн хугацаа орох вэ, хэлээд өгөөч?

- Одоо үдийн нэг цаг болж байна, гурав дахь өдрийн орой Нуувчид хүрэх ёстой. Тэр шөнө тэргэл сартай байна. Эзэн цугларалтыг маргааш өдөр нь товлосон. Бүх Ристаниас түүнээс хурдан цугларч амжихгүй – гэж Эорен хариулав..

- Гурав хоногийн дараа гэнэ ээ - хэмээн Арагорн бодолдоо автан хэлээд: - Цэргийн цугларалт дөнгөж эхэлж байна. Тийм ээ, үүнээс хурдан гэж байхгүй, энд яарах ямар ч шаардлага алга – гээд тэр харцаа дээш өргөхөд царай нь гэрэлтэн, амаргүй бэрх шийдвэр дөнгөж сая хийсэн шиг харагдав: - Тэгвэл эзэн минь, та зөвшөөрвөл бид зам салъя. Манай садан төрлийнхөн өөрийн замтай, бид одоо ил явъя. Надад одоо нуугдах хэрэгцээ байхгүй. Дорно зүг рүү хамгийн дөт замаар явъя, цаашаа үхдлүүдийн замаар явъя.

- Үхдлүүдийн зам аа! - хэмээн Теоден овгосхийн цочиж: - Чи юу яриад байна аа?

Эомер Арагорн руу гайхан харахад энэ үгийг сонссон дайчдын царай шохойноос цагаан болох шиг санагдав.

- Хэрэв үнэхээр тийм зам байдаг юм бол Дунхергийн ойролцоох хаалганаас эхэлнэ, гэвч тэнд очиж байсан хэн ч байхгүй – гэж Теоден хэлэв.

- Арагорн, анд минь дээ! - гэж Эомер толгой сэгсрээд: - Бид мөр зэрэгцэн тулалдана гэж бодсон юмсан. Гэвч хувь заяа чамайг үхдлүүдийн зам руу дуудаж байгаа бол бид салахаас даа, харин энэ ертөнцөд дахиад уулзахгүй л болов уу.

- Надад өөр зам алга аа – гэж Арагорн хариулаад: - Гэлээ ч гэсэн, Эомер минь, бид Мордорын бүх сүргийн хоёр талаас цавчилдсаар тулааны талбарт дахин уулзаж ч магадгүй шүү.

- Бодсоноороо л хий, эзэн хаан Арагорн минь, - гэж Теоден хэлээд - Чиний хувь заяа хэний ч яваагүй газраар чамайг явуулдаг юм шиг байна. Чамаас салахад надад хичнээн хэцүү байлаа ч гэсэн биднийг уулын зам хүлээж байна. Алгуурлаж болохгүй. Баяртай!

- Баяртай эзэн минь! - гэж Арагорн хэлээд: - Агуу их алдрынхаа өөдөөс угтан давхи даа! Мерри, чи ч гэсэн баяртай! Чи сайн гарт үлдлээ, бид Фангорн хүртэл орхуудтай хөөцөлдөж явахад би ийм сайхан юм болно гэж найдаагүй юм шүү. Леголас, Гимли хоёр намайг дагах байх, гэхдээ бид чамайг мартажгүй ээ.

- Баяртай! - гэж Мерри арайхийж хэлэв. Түүнд өөр үг олдсонгүй. Тэр өөрийгөө хариугүй өчүүхнээр төсөөлж байв. Түүний сая сонссон баргар үгс дарамтлаад байв. Хэзээ ч үл гунихрагч Пин одоо хүрээд ирдэг ч болоосой! Морьт дайчид бэлэн зогсч, морьд нь хөлөө тэвчиж ядан сэлгэж, хурдхан ухасхийн давхих гэж байж ядан байна.

Теоден Эомер руу харахад цаадах нь гараа өргөн чанга дуугаар тушаал өгөхөд морьт дайчдын цуваа хөдөллөө. Тэд Хавцлын хонхроос гарч, дорно зүг рүү огцом эргэн, уулын бэлээс нэг бээрийн зайтай замаар орж, өмнө зүг рүү эргээд ууланд хүрлээ. Арагорн өндөрлөг өөд гарч, ристанчуудыг далд ортол харж зогсов.

- За ингээд миний зүрхэнд ойр гурван хүн яваад өглөө. Энэ жижиг бараг л хамгийн ойр нь байх даа. Тэр урд нь юу хүлээж байгааг мэдэхгүй, хэрэв мэдсэн ч явах байсан даа – гэж тэр Гальбарадад хэлэхэд:

- Тийм ээ, жижиг биет хоббитуудыг нуруугаар нь хэмжиж болохгүй, бид тэдний хил хязгаарыг ямар их хөдөлмөрөөр хамгаалж байсныг тэд огтхон ч мэдэхгүй, гэлээ ч гэсэн би үүнд гомдохгүй л дээ.

- Одоо бидний хувь заяа нэг зангилаанд зангилагдсан. Гэхдээ яахав дээ, салах цаг болоход салахаас л яахав. За за, би нэг жаахан юм идээдхэе, тэгээд замдаа гаръя даа. Леголас, Гимли, явцгаая! Хоол идэнгээ ярилцъя.

Тэд Горнбург руу буцаж оров. Гэвч Арагорн хоолны ширээнд дуугаа хураасан хэвээр, андууд гайхсан харц солилцон сууж байв.

- Ярь, ярь! – гэж эцэст нь Леголас хэлээд – Ядаж сэтгэл зүрх чинь хөнгөрнө биз дээ! Бид манант үүрээр энэ уйтгарт цайз руу орж ирснээс хойш юу болсон юм бэ?

- Би энэ уйтгарт цайзын хананаас хамаагүй хатуу ширүүн тулалдаанаас сая гарч ирлээ. Би Ортханы чулуу руу харлаа шүү дээ, андууд минь – гэж Арагорн хэлэв.

- Чи тэр хараал идсэн хар юм руу харлаа гэж үү? – хэмээн Гимли айдас, гайхаш хоёр нүдэндээ тодруулан хашгираад: - Тэр... Дайсан чамаас ямар нэг юм мэдэж авсан уу? Гэндальф хүртэл ийм халз тулаанд зориглож ордоггүй байтал чи...

- Чи хэнтэй ярьж байгаагаа мартаад байна – гэж Арагорн түүний үгийг ширүүхэн таслаад, нүд нь гялалзан:

- Би Эдорасын хаалган дээр чиний дэргэд бүгдэд сонсогдохоор тунхаглан зарлаагүй гэж үү? Чинийхээр бол би Дайсанд юу хэлчих байсан юм бэ? Үгүй дээ, үгүй, Гимли минь, - гээд тэр дуугаа намсган ярихад түүний нүүрнээс сүүдэр арилж, зөвхөн олон хоног амралтгүйгээр хүнд хүчир ажил хийсэн юм шиг ядаргаа л нүүрэнд нь тодорч:

- Үгүй дээ андууд минь, би тэр чулууны хууль ёсны эзэн, би түүнийг өөрийнхөө хүссэнээр хэрэглэх эрхтэй. Миний эрх маргаангүй. Миний хүч хүрэлцсэн, гэхдээ арай гэж л.

Тэгээд тэр гүнзгий санаа алдав.

- Тиймээ, үнэхээр хүнд тулалдаан байсан, одоо ч гэсэн ухаан санаа хэвэндээ орохгүй л байна. Би тэрэнд нэг ч үг хэлээгүй, гэвч чулууг өөрийнхөө хүсэл зорилгод захируулж байсан. Зөвхөн энэнээс болоод л тэр солиорно биз дээ. Би яг тэрний өмнө очоод зогсчихсон. Тиймээ, ноёнтон Гимли минь, Дайсан намайг харсан, гэхдээ одоо чиний харж байгаагаас өөр дүрээр харсан. Хэрэв би тэрэнд сайн үйлчилсэн бол бидний ажил хэрэг муугаар дуусна, гэвч би тэрэнд муу үйлчилгээ хийсэн гэдэгтээ бат итгэлтэй байна. Миний ойлгосноор тэр намайг амьд байгааг хараад мэл гайхах шиг болсон. Яагаад гэвэл тэр намайг эртнээс мэднэ, тэгсэн мөртөө миний тухай нарийн юм юу ч мэдэхгүй. Аз болоход Ортханкийн цонхон доор хэн ч

намайг анзаараагүй, би Ристанийн хувцастай байсан, гэвч Саурон Исилдур болон Элендилийн илдийг мартаагүй байсан.

Тэгээд тэрний хар санаа биелэлээ олж эхлэнгүүт тэр Исилдурын залгамжлагчийг, бас түүний домогт илдийг өөрийн нүдээр харсан, би шинээр давтсан илдийг сугалж харуулсан юм. Тэр юунаас ч айхгүй тийм агуу хүчтэн биш ээ, тэр их л эргэлзэж байна лээ.

- Тэр хүчээр дутахгүй, одоо цохилтоо улам ч хурдан хийх болно доо – гэж Гимли зөрөв.

- Хурдан гэдэг бол зөв гэсэн үг биш, одоо тэрний дайралтыг хүлээж суух цаг биш, түрүүлж цохилт өгөх цаг. Андууд минь би тэр чулууг эзэмдэхэд надад олон юм нээгдсэн шүү. Гондорт өмнө талаас нь аюул нөмөрсөн байна, Минас-Тиритийн хамгаалагчид хоёр дахин цөөрсөн байна. Хэрэв бид тэр аюулыг нэн даруй арилгахгүй бол тэр хот сөнөнө, арав хоног ч тэсэхгүй – хэмээн Арагорн ярихад:

- Тэгвэл тэртэй тэргүй л сөнөх юм байна шүү дээ, хэн тийш нь тусламж явуулах юм бэ, яаж амжиж тэнд хүрэх юм бэ?

- Туслахаар илгээх хүч алга, тиймээс өөрөө л явах хэрэгтэй. Тэнгист амжиж хүрэх ганцхан л зам бий, одоохондоо бүх юмаа алдчихаагүй дээрээ амжиж очих хэрэгтэй. Энэ зам бол үхдлүүдийн зам.

- Үхдлүүдийн зам! - гэж Гимли давтаад – Зэвүүн нэр байна даа, ристанчуудын чихэнд тийм нэр чимэгтэй сонсогддоггүй л байх. Тэр үхдлүүдийн замаар чинь амьд явж болох юм уу? Тэр замаар амьд яваад хүрлээ ч гэсэн Мордорын тоо томшгүй их хүчний өөдөөс бидний хэдэн дайчин юу болох вэ дээ!

- Тэр замаар амьд амьтан явж байгаагүй байх. Мустангримчүүд тийм тохиолдлыг санадаггүй юм билээ. Тэр бол амь бүхэнд хаалттай зам. Гэвч Исилдурын залгамжлагч зориглох юм бол тэр хар нүхээр амьд гарч чадна. Сонсоцгоо андууд минь! Уудам хөндийн Элрондын хөвгүүд надад эцгийнхээ захиас үгийг дамжуулсан: Арагорн зөнчийн үгийг санаж, үхдлүүдийн замыг санаг! гэж эртний бүх домгийг мэддэг тэр мэргэн хэлүүлсэн байна.

- Зөнчийн үг гэдэг нь юу юм бэ? - гэж Леголас асуув.

- Форпостын сүүлчийн эзэн захирагч Арведуйн үед мэргэн зөнч Мальбет ингэж хэлсэн юм:

Гамшигийн хар сүүдэр

Газар дээгүүр нөмрөнө:

Хот суурин доргиж

Хогнууд авс руугаа мөлхөнө.

Яагаад ингэв гэвэл

Ялтнуудын хоногийг тоолно.

Амьд дайснууд бүгдээрээ

Алга болсон учраас

Амгүй үхдлүүд цөмөөрөө

Авсан дотроосоо босно.

Эрекийн оргил дээрээс

Эвэр бүрээ дахиад цууриална.

Хэн түүнийг үлээх вэ?

Хэзээ ч сэрэхгүй нойрноос

Хэн тэднийг сэрээх вэ?

Үхдлүүдийн харанхуй замаар

Үнэнч зүтгэж ирэх

Үйлгүй үнэн эзэн байнам.

- Харанхуй замаар гэдэг нь ч ойлгомжтой байна, харин бусад нь тун ч ойлгомжгүй шүлэг байна – гэж Гимли хэлэв..

- Хэрэв чи надтай хамт харанхуй замаар явах юм бол бусад нь ойлгомжтой болно. Би өөрөө бол тийм зам сонгомооргүй л байлаа, гэвч заяагаар заасан юмнаас зайлж болдоггүй юм шиг байна аа. Харин та нар минь яахаа өөрсдөө шийд, дарахын аргагүй айдсыг дарж, туулахын аргагүй бэрхшээлийг туулах эр зориг, хүч чадал байна уу, үгүй юу гэдгээ бод.

- Тэр үхдлүүдийн зам чинь хаашаа ч хүрдэг байсан хамаагүй би чамтай хамт явна - гэж Гимли хэлэв.

- Би ч гэсэн явна, үхдлүүдээс айх юу байдаг юм бэ - гэж Леголас хэлэв.

- Мартагдсан тэр ардууд дайн тулааны ажлыг мартаагүй бол сайнсан, мартчихсан бол тэднийг түгшээгээд яахав – гэж Гимли хэлэхэд:

- Энэнийг бид Эрекийн оргилд амьд мэнд хүрвэл мэдэх болно, тэд Сауронтой тулалдана гэж андгайлаад дараа нь тангаргаа мартчихсан юм. Одоо тэр тангаргаа биелүүлэхийн тулд тулалдах хэрэгтэй. Исилдур Нуменороос авчирсан хар чулуугаа Эрекийн оргил дээр тавьсан гэж домогт өгүүлдэг. Түүнийг төр барьж байх эхэн үед уулынхан Гондорт үнэнч зүтгэхээ тэр чулууны дэргэд андгайлсан гэдэг юм. Дундад газарт Хар эзэн гарч ирээд дахин хүчирхэг,

аймшигтай болоход Исилдур уулынхныг агуу их тулаанд уриалсан боловч тэд татгалзсан. Учир нь тэд Сауроны хаанчлалын хоёрдугаар эринд түүнд сэм урвасан байсан.

Тэгэхэд нь Исилдур Гондорын ванд: “Чиний төр Гондорын сүүлчийн төр болно. Хэрэв өрнөд чиний орныг эзэлбэл би чамайг болон чиний ардуудыг хараана. Та нар тангаргаа билүүлээгүй цагт нэг ч өдөр амгалан тайван байхгүй. Яагаад гэвэл энэ дайн тоолшгүй олон жил үргэлжилж эцсийн эцэст та нарыг тулааны талбарт дуудна” гэж хэлсэн юм. Тэгээд уулынхан Исилдураас айж, Сауроны талд байлдаагүй, ууландаа бүгээд, хөрш орнуудаас тасарч, тэр хад чулуун цөлдөө аажмаар сөнөж эхэлсэн.

Гэвч үхэгсэд оргүй алга болоогүй, тэдний сүнс сүүдэр Эрекийн эргэн тойронд айдас төрүүлсэн. Нэгэнт надад амьдуудаас нь тусламж ирэхгүй учир би тэр замаар явна – гээд Арагорн босч бүрэнхийд тод гялалзах илдээ сугалан: - Урагшаа! – Би үхдлүүдийн замаар Эрекийн чулуунд хүрнэ. Хэн зориглосон нь миний араас! – хэмээн захирлаа.

Леголас, Гимли хоёр түүний араас дуугаралгүй гарч, юүдэнгээ буулган жагссан морьт дайчид руу очлоо. Тэр хоёр мориндоо мордоход Арагорн ч Рогерин мориндоо мордов. Гальбарад эвэр бүрээгээ үлээхэд бүрэн дуу Хельмийн хавцлыг доргион хүнгэнэлээ. Дайчид хонхроос салхи шуурга мэт дүүлэн гарч давхихад ард үлдэгсэд тэдний хойноос гайхан харж хоцров.

Теоден уулын замаар удаан урагшилж байхад Саарал бүлэг талаар давхиж маргааш нь гэхэд Эдораст дөхөж ирлээ. Түр зуур морьдоо амраагаад цааш давхиж, бүрий болоход Дунхерг хүрэв.

Хатан хаан Эовин тэднийг баяртайяа хүлээж авлаа. Дунаданчууд болон Элрондын хөвгүүд шиг ийм хүчирхэг баатар вангуудыг урьд нь тэр нэг ч удаа харж байгаагүй бөгөөд Арагорнаас бараг нүдээ салгаж чадахгүй байв. Оройн зоогийн үеэр тухтай ярилцаж, хатан хаанд Теоден нийслэлээс явснаас хойш юу болсныг бүгдийг ярьж өгөв. Хатан хаан хаа нэг бүдэг бадаг сураг л сонсч байжээ. Одоо тэр Хельмийн цайзад болсон тулалдаан, дайсныг бүрэн бутниргэсэн, эзэн захирагч морьт цэрэгтэйгээ сүүлчийн тулаанд явсан тухай сонсоод хатан хааны царай гэрэлтэв. Тэгээд:

- Баатрууд минь, замын алжаалаа тайлж амарцгаа. Одоо орой болсон тул би та нарыг дариухан амраая. Маргааш өглөө ч та нарыг тухтай амраая – гэлээ.

Гэвч Арагорн:

- Хатан хаан минь, энэ талаар бүү санаа зов. Бид зүгээр л унтаж хоноод өглөөний хоол идээд л мордоно. Би маш их яарч байна, бид үүрээр мордоно.

- Тэгвэл чамд баярлалаа эзэн минь, - хэмээн хатан хаан инээмсэглээд: - Чи зожиг эм Эовинд сайн мэдээ дуулгах гэж замаасаа гажин олон бээр давхиж ирсэн байх нь ээ.

- Ийм зожиг эм байдаг бол түүний төлөө замаасаа гажиж олон бээр давхих юу ч биш, гэхдээ хатан хаан минь би замаасаа гажаагүй.

- Тэгвэл эзэн минь, Дунхерийн хөндийгөөс зүүн зүг рүү ч, өмнө зүг рүү ч явах зам байхгүй учраас чи гэдрэг буцахын тулд замаасаа эргэсэн байх нь ээ – гэж хатан хаан гунигтайхан хэлэхэд:

- Үгүй ээ, хатан хаан минь, би замын дундаас буцаагүй. Энэ хязгаар нутгийн чимэг болж төрөхөөс чинь өмнө би энэ нутгаар зөндөө тэнэж байсан. Энэ хөндийгөөс гарах гарц бий, тэр гарц л надад хэрэгтэй байна, эндээс өмнө зүг рүү үхдлүүдийн замаар явдаг юм.

Хатан хаан аянганд ниргүүлсэн юм шиг болж, царай нь цайн Арагорны нүд рүү ширтэн таг чимээгүй суухад бүгд нам гүм болов.

- Арагорн, - гэж хатан хаан эцэст нь дуугарч: - Чи үхэл рүү яарч яваа юм гэж үү? Энэ замд чамайг зөвхөн үхэл л тосно. Түүгээр амьд амьтан гаргахгүй.

- Намайг гаргачих байх аа, ямар ч байлаа гэсэн би гарах гээд үзнэ. Надад өөр зам тохирохгүй

- Гэвч энэ чинь ухаангүй явдал. Алдар цуутай, эрэлхэг баатрууд чамайг дагаж явна, чи эднийг үхэл рүү биш, тулааны талбар руу дагуулах ёстой. Чамаас сөгдөж гуйя, энд үлдээд миний дүүтэй хамт яв, тэр бол нийт Ристаний дайчдын манлай, чи агуу их найдварын бэлэг тэмдэг болж түүнтэй хамт яв.

- Үгүй ээ, хатан хаан минь энэ бол ухаангүй явдал биш, энэ замыг аль эрт надад зааж өгсөн юм. Надтай хамт явах нь яваг, эндээ үлдээд ристанчуудтай явах нь үлдэг. Харин би үхдлүүдийн замаар ганцаараа ч хамаагүй явна.

Дахиад хэн ч юу ч хэлсэнгүй, оройн зоог чимээгүй үргэлжилж, Эовин Арагорныг нүд цавчилгүй ширтэн суухад хоёр нүд нь гуниг дүүрэн байлаа. Тэгээд бүгд босч хатан хаанд тавгай нойрсохыг ерөөгөөд унтахаар гарцгаав.

Арагорныг Леголас, Гимли хоёртой нэг асарт оруулав. Асар руу явж байхад хатан хаан түүнийг дуудлаа. Тэр эргэж харахад шөнийн харанхуйд гэгээ татах шиг болов. Хатан хаан цав цагаан өмсгөлтэй, нүд нь очтон гялалзаж байв.

- Арагорн, чи яах гэж тэр үхлийн зам руу тэмүүлээд байгаа юм бэ?

- Өөр зам байхгүй учраас л, зөвхөн би л Сауроноос урьтаж магадгүй. Би үхлээ эрж яваа юм биш ээ, Эовин. Миний хүслээр болдогсон бол одоо би Уудам хөндийн гэрэлт жимээр зугаалж явах байлаа.

Эовин дуугарсангүй, түүний сүүлчийн өгүүлбэрийг бодож байв. Тэгээд гэнэт түүний мөрөн дээр гараа тавьж:

- Чи хатуу ширүүн хүн. Чам шиг хүнд л суу алдар ирдэг юм – гээд дахин дуугүй болсноо эцэст нь шийдвэр төгс хэлэв: - Эзэн минь, хэрэв чиний замыг тэгж заасан юм бол намайг аваад яв. Би нуугдаж ханалаа, одоо үхэх сэхэхээ үзэх тулаанд өөрийгөө соримоор байна.

- Чи ард түмэнтэйгээ байх ёстой шүү дээ.

- Тэгэх ёстой, ингэх ёстой гэсэн үг л сонсох юм! – гэж Эовин хашгирах шахам хэлээд: - Би Эорлын удам биш юм уу? Би дайчин хатан хаан юм уу, асрагч эмгэн юм уу? Олон жил би босох ч тэнхэлгүй өвгөнийг сахилаа. Тэр одоо хөл дээрээ боссон юм шиг байна, би үлдсэн амьдралаа өөрийнхөө хүслээр өнгөрөөж болохгүй гэж үү?

- Ингэж бараг хэн ч болохгүй, хатан хаан чамаас өөр хэн эзэн захирагчийг ирэх хүртэл ард түмнээ аварч хамгаалах юм бэ? Хэрэв эзэн захирагч чинь чамд биш хэн нэг жанжинд юм уу, ванд улс орноо итгэж даатгасан бол тэр нь ямар ч үед итгэлийг хөсөрдүүлэх байсан уу?

- Тэгэхээр үргэлж ийм байх юм уу? – гэж хатан хаан гунигтайяа асуугаад: - Дайчид дайн байлдаанд явж алдар хүндийг олж, би эндээ үлдээд л, орон гэрийг нь сахиад л, тэднийг хүрээд ирэхээр нь угтаж аваад л, хоол унд, ор дэрийг нь бэлдээд л, тийм үү?

- Угтаж авах хэн ч ирэхгүй байж болно. Алдар хүндийг олохгүй баатарлаг гавьяаны цаг ирж ч мэднэ. Төрөлх орноо хамгаалсан сүүлчийн баатруудын гавьяаг хэн ч мэдэхгүй өнгөрч болно. Гэхдээ алдар хүндгүй гавьяа алдар хүндтэй гавьяанаас яагаад ч доор байх ёсгүй.

- Чи нэг л юм давтаад байх юм. Эмэгтэй хүн орон гэрээ л сахих ёстой гэнэ. Хэрэв дайчид маань баатарлагаар амь үрэгдвэл эмэгтэй нь үхсэн хүнд хэрэггүй учир орон гэртэйгээ шатах хэрэг үү? Би шивэгчин эм биш, Эорлын удам залгасан хатан хаан. Үхлээс ч айхгүй, гамшиг зовлонгоос ч айхгүй.

- Хатан хаан та юунаас айдаг вэ?

- Алтан торноос айдаг, гэрийн жаргалдаа дасч, хөгшрөөд агуу их гавьяаны тухай мөрөөдлөөс салахаас айдаг.

- Тэгвэл чи намайг аюултай замаар бүү яв гэж яах гэж ятгаад байгаа юм бэ?

- Би өөрийгөө ятгаагүй, чамайг ятгасан. Би чамайг аюулаас зугтаа гэж ятгаагүй, шийдвэрлэх тулаанд орж, эр зориг, илд сүрээрээ ялалт, алдар суугаа олж ав гэж ятгасан. Би чиний алдар суу, агуу гавьяа чинь хий хоосон үрэгдэхийг л хүсэхгүй байна!

- Би ч гэсэн тэгж хүсэхгүй байна. Тийм учраас чамайг эндээ үлд гэж байгаа юм, хатан хаан минь! Өмнөд газарт чамд хийх юм байхгүй.

- Чамайг дагаад явах бусад хүмүүст ч тэнд хийх юм байхгүй. Тэд зүгээр л чамаас салж чадахгүй болохоороо, чамд хайртай болохоороо явж байгаа юм.

Ингэж хэлээд хатан хаан цааш эргэж, харанхуйд алга болов. Тэнгэр гэгээрсэн боловч нар дорнын өндөр уулсын цаанаас мандах хараахан болоогүй байлаа. Дайчид мориндоо мордож, Арагорн мориндоо мордох гэж байтал хатан хаан Эовин хуяг дуулгаа өмсч, илдээ агсаад тэдэнтэй салах ёс хийхээр гарч ирэв. Тэрбээр хундага дарс барин ирж, дайчдад сайны ерөөл өргөөд, дарснаас амсч, хундагаа Арагорнд өгөв. Арагорн дарсыг хөнтрөөд:

- Баяртай, Ристани хатан хаан! Би чиний төлөө, танай ард түмний төлөө, танай эзэнт

төрийн төлөө уулаа. Бид харанхуйг гэтлэн даваад уулзана гэж дүүдээ хэлээрэй!

Хатан хааны бардам бөгөөд сүрлэг царай уй гунигаар сүүдэртэж, дотроо чимээгүй уйлж байгааг Гимли, Леголас хоёр харлаа. Тэгтэл хатан хаан:

- Арагорн, чи явна гэсэн замаараа явах уу?

- Тэгнэ ээ.

- Миний гуйлтыг зөвшөөрч намайг дагуулж явахгүй юу?

- Үгүй ээ, хатан хаан минь, чи эзэн захирагч юм уу, дүүгийнхээ зөвшөөрөлгүйгээр явж болохгүй, гэтэл тэр хоёр маргаашаас л ирнэ. Надад цаг мөч болгон үнэтэй байна. Баяртай!

Тэгтэл хатан хаан өвдөг сөгдөөд:

- Би чамаас гуйж байна шүү дээ!

- Үгүй ээ, хатан хаан минь, - гэж Арагорн эрс хэлээд түүний гараас татан босгож, дараа нь гарыг нь үнсээд мориндоо үсрэн мордож, эргэж ч харалгүй ергүүлэв. Түүнийг сайн мэддэг, хажууд нь явж байгаа нөхөд нь түүний сэтгэл ямар их хямарч байгааг харж байлаа.

Эовин хөшөө мэт хөдөлгөөнгүй зогсоод, хумсаа алгандаа шигдтэл гараа атган сүгийн уулын сүүдэр рүү, үхмэл хязгаарын үүд рүү одож байгаа тэдний араас харсаар байлаа. Морьтнуудын цуваа нүдэнд үзэгдэхгүй болоход тэр асар руугаа найган гэлдрэв. Түүний албатуудаас нэг ч хүн энэ үдэлтийг харсангүй, үүр цайж, тэнэг мугуйд харийнхныг явгал нуугдан хүлээж байжээ.

Хүмүүс:

- Энэ чинь эльфүүд байна. Тэр үхмэл хязгаарт үхэх газрынх нь шороо пурхийсэн бол явж л байг цаашаа. Бидэнд өөрийн зовлон хангалттай - гэцгээв.

Үүрийн гэгээ бүүдгэрхэн гийгүүлж, мандах нарыг сүгийн өндөр уул халхалж байлаа. Эртний чулуун хананы хоорондуурх муруй тахир зам тэднийг аймшигт хязгаарын үүд Димхолтын шугуй руу хөтөллөө. Леголаст хүртэл зэвүүн санагдсан хав хар моддын дундуур явсаар уулын ам руу орж ирэхэд замын тэг дунд асар том багана гараад ирэв.

- Яагаад ч юм миний цус царцаад байна – Гимли хэлэхэд хэн ч хариулсангүй, түүний дууг газраар нэг хөглөрсөн нойтон шилмүүсэн дэвсгэр залгив.

Морьд зэвүүн баганы дэргэд ирээд зогсоход дайчид бууж, морио хөтлөн эгц хажуугаар баганыг тойрон газрын гав мэт нүхэн үүд харлаж буй уулын бэл рүү дөтлөв. Өргөн нуман хаалганы дээгүүр нууц бичээс болон нууцлаг зурагнууд бүдэгхэн харагдаж, үхлийн уйтгар мэт саарал манан үүдийг бүрхжээ. Дайчид айсандаа хөшөө мэт хөшиж байхад ганцхан эльфүүдийн хан хүү Леголас л огт тоосонгүй, тэрбээр хүний сүнс сүгийг өчүүхэн ч хэрэгсдэггүй ажээ.

- Энэ үүдний цаана үхэл нуугдаж байна. Би тэрний өөдөөс очно, харин морьд л явахгүй дээ - гэж Гальбарад хэлэв.

- Бид үүгээр гарах ёстой, тэгэхээр морьд ч явна. Үүдний цаана үхлийн харанхуй байгаа, тэрний цаана алсын зам байгаа, мөч, хором бүрт алгуурлавал Саурон ялна. Урагшаа! – гэж Арагорн захирав.

Тэгээд Арагорн түрүүлэн үүд рүү орлоо. Түүний агуу хүсэл зоригт урам зориг орсон дунаданчууд араас нь дагаж орлоо. Тэдний морьд эзэндээ дэндүү их хайртай, унаж яваа эзнийх нь зүрх дэндүү найдвартай учир эзэнтэйгээ хамт байгаа цагт чөтгөр шулмаас ч эмээдэггүй ажээ. Зөвхөн Ристаний морь Арод л хүйтэн хөлс асгаруулан чичирч, харахад өрөвдмөөр байв. Гэвч Леголас түүний нүдийг алгаараа хааж байгаад чихэнд нь энхрий зөөлнөөр хэдэн үг хэлэхэд морь тайвширч, эзнээ даган оров. Үүдний өмнө зөвхөн гном баатар Гимли үлдэв. Түүний өвдөг салганан чичирч, өөрийгөө зоригжуулахын тулд ичээх гэж:

- Ёстой сонссоогүй юм байна, эльф газар доогуур шууд яваад орчихож байхад гном айж байх гэж үү? – гээд тугалга цутгасан юм шиг дуулгаваргүй хөлөө захиран ухасхийж ороход хав харанхуй нөмрөн авч, ямар ч нүх, хонгил руу аймшиггүй яваад ордог байсан Глоины хүү Гимли юу ч харахгүй болов.

Арагорн Дунхергээс бамбар нөөцөлж гарсан тул бамбараа барин түрүүлж, Элладан цувааны сүүлд бас бамбар барьж, түүний араас Гимли бүдэрч бүдчин алхав. Тэр зөвхөн бамбарын бүдэг гэрлийг л харж байсан бөгөөд чихэнд нь үл ойлгогдох хэлээр үй олон шаагилдан ярих чимээ сонсдов.

Дайчид ямар ч саадгүй урагшилсаар байхад гном баатарт улам л аймшигтай болж байсан ч буцах зам байхгүй гэдгийг мэдэж байсан тул нөхдийнхөө араас зүтгэлээ. Цаг маш удаан өнгөрч, Гимли эцэст нь санах маш дургүй юм аа үзэв. Тэд өргөн хонгилоор явж байгаа юм шиг байснаа гэнэт хананууд алга болж, өмнө нь хараа гүйцэшгүй хоосон орон зай гараад ирэв. Айдас хамаг биеийг нь хүлсэн учир алхам бүрдээ өвдөг нь нахисхийж байлаа. Зүүн талд нь ямар нэг юм гялсхийж, Арагорны бамбар ойртож ирэв. Тэнд юу гялалзаад байгааг харах гэж Арагорн эргэсэн бололтой.

- Энэ одоо айдаггүй юм байх даа? Глоины хүү Гимли үүнээс өөр ямар ч агуйд алт гялалзаж байвал хамгийн түрүүнд гүйгээд орно доо. Харин энд бол үгүй шүү! Тэндээ хэвтэж л байг! – гэж бувгнав.

Гэлээ ч гэсэн тэр тэсч чадсангүй алхаж очиход Арагорн өвдөг сөгдөн сууж, Элладан хоёр бамбар барьж байгааг харав. Тэдний өмнө нэгэн баатрын араг яс байлаа. Байлдааны өмсгөл нь бүтэн байв. Хөө хуяг нь алтадмал, агуй дахь агаар арай хэтэрхий хуурай, бараг л шүдэнд ширжигнэж байлаа. Бүс нь алт, боржин чимэгтэй, алтан туузтай дуулга бүхий гавал нь нүүрээрээ элс рүү шаан унажээ. Бамбарын гэрэлд харахад араг яс агуйн хананы дэргэд, чулуун хаалганы завсраас хоёр гараараа зууран хэвтэж байв. Хажууд нь хөрөө шиг иржийсэн иртэй илд хэвтэнэ. Тэр баатар амь тасраагүй байхдаа илдээрээ чулуун хаалгыг байдаг хүчээрээ цавчсан бололтой.

Арагорн тэдгээрт гар хүрсэнгүй, дуугүй харж байснаа босч санаа алдаад:

- Энэ эринийг дуустал эдгээрийн дээр цэгээн цэцэг дэлгэрэхгүй. Есөн шарил, дээр нь долоон шарил дээр аль эрт өвс ногоо ургасан байна, энэ баатар нээж чадаагүй хаалганыхаа дэргэд хэдэн он хэвтэж байгааг хэн мэдлээ. Энэ хаалга хаашаа оруулдгийг хэн ч мэдээгүй. Энэ баатар энэ хаалганы цаанаас юу олох гэснийг ч бас хэн ч мэдэхгүй. Хэзээ ч, хэн ч мэдэхгүй... Надад үүнийг мэдэх хэрэгцээ байхгүй! – гэж тэр ардаа зогсч буй дайчдад хэлээд: - Хараалт эриний хар нууцыг хадгалж үлдэцгээ дээ! Харин бид яарах хэрэгтэй байна. Биднийг нэвтрүүл, тэгээд араас дага! Би бүгдийг Эрекийн чулуу руу дуудаж байна! – гэлээ.

Түүний үгэнд хариу сонсогдсонгүй, аймшигт ширжигнээнээс ч илүү аюултай нам гүм болоод бамбарын гэрэл дүрсхийн маналзсанаа унтрав. Бамбаруудыг дахиад асааж чадсангүй. Цааш нь юу болсон, хичнээн хугацаа өнгөрсөнийг Гимли мэдсэнгүй. Дайчид урагшлан давхисаар, Гимли айдсаа арай ядан дарж, тэднийг арай ядан гүйцэж явав. Элдэв янзын, тоо томшгүй шаржигнаан, сүржигнээн, түржигнэн, наржигнаан юу юугүй гүйцэн амийг нь авах гэж байгаа юм шиг санагдана. Тэр явж чадахаа больж, бүдэрч унан, дөрвөн хөллөн мөлхөж, цаашаа явж чадахгүй гэдгээ мэдэрч байв. Нэг бол гарах гарц, аврах зам нээгдэнэ, нэг бол юу л болбол болог гэж бодонгуугаа тэр аймшгуудын өөдөөс ухасийн гүйв.

Гэнэт тэр хаа нэгтээ газар том чулуу өнхөрч хар дарсан зүүднээс сэрээж байгаа юм шиг тов тодхон ус хоржигнохыг сонсов. Гэгээтэй болж, дайчид өндөр нуман хаалгаар гарч ирэв. Хажуугаар нь горхи урсч, өмнө нь тэнгэрт тулам өндөр хясаануудын дундуурх хавцал руу орсон зам зурайж байлаа. Хавцал дэндүү нарийхан байсан тул тэнгэр бараг харагдахгүй, нарийхан зурвасаар одод л жирвэлзэнэ. Гэвч тэдний Дунгхергээс гарсан өдөр дуусаагүй, нар жаргах хүртэл дахиад хоёр цаг байгааг Гимли дараа нь мэдсэн бөгөөд огт өөр ертөнцөд ороод ирсэн мэт санагдаж байв.

Дайчид дахин цуваанд орж, Гимли Леголасын араар сундалдаж явлаа. Харуй бүрий болж, аймшиг араас нь нэхсээр байлаа. Леголас эргэж харахад Гимли эльф баатрын гялалзсан хоёр нүдтэй харц тулгарав. Элладан цувааны ард явж байсан боловч энэ зам дээрх хамгийн сүүлчийн зорчигч биш байжээ.

- Үхдлүүд араас хөөж байна, би морьтой сүүдрүүдийг харж байна. Уранхай даавууны өөдөс шиг тугнууд, өгөршсэн мод шиг жаднууд харагдаж байна – гэж Леголас хэлэв

- Тийм ээ, үхдлүүд хоцрохгүй дагаж байна. Тэд дуудлагад хариулж байна – гэж Элладан хэлэв.

Дайчид эцэст нь ханан цоорхойгоор гараад ирж байгаа юм шиг гэнэтхэн хавцлаас гараад ирлээ. Тэд өндөр уулын хөндий рүү орж, хүрхрээний чимээ сонсогдов.

- Бид хаана хүрээд ирэв ээ? - гэж Гимли асуухад Элладан:

- Хүйтэн голын хөндийд ороод ирлээ. Энэ гол Дол-Амротын хэрэмд тулдаг тэнгисийн буланд цуггадаг юм. Мортхонд гэдэг нэртэй, хав хар устай гол байдаг юм. Яагаад хар устай юм бэ гэж асуухгүй юм байгаа биз дээ - гэлээ.

Мортхондын хөндий өмнө талын эгц өндөр уулыг ороожээ. Тэртээ доор суурингийн гал гялалзаж харагдав. Энэ хөндий үржил шимт хөрстэй учир суурьшигчид олон ажээ.

Арагорн эргэж харалгүй:

- Андууд минь ядрахыг март! Давхиад бай! Бид шөнө дундаас өмнө Эрекийн чулуунд хүрсэн байх ёстой, тэр хүртэл бас л их зай бий – гэж хашгирав.

Дайчид эргэж ч харалгүй давхин голын гүүрээр гарч, цааш хөндий уруудсан замаар хурдаллаа..

Энд тэндгүй галаа унтраан хаалгаа түгжиж, тариа ногооны талбайд байсан хүмүүс айсан армаан мэт хашгиран зугтаж байв.

- Үхдлүүдийн арми! Үхдлүүд бидэн рүү довтолж байна! – хэмээн хашгиралдах сонсогдоно.

Хонх цуурайлж, гадаа байсан хүмүүс бүгд зугтаан нуугдаж байлаа. Саарал бүлэг морьдоо бүдэрч эхлэх хүртэл шуурхайлан давхисаар байв. Шөнө дундын өмнөхөн тэд Эрекийн чулуунд давхиж хүрэв.

Аль дивангараас нааш Эрекийн уулс болон эргэн тойрны тал хөндийд үхээрийн аймшиг нөмөрч иржээ. Уулын орой дээр асар том бөмбөлөг мэт бөөрөнхий хар чулуу байх бөгөөд тал нь газарт шигдсэн ч гэсэн босоо хүний дайтай өндөр байв. Тэр бул чулуу эндхийнх биш бөгөөд тэнгэрээс унасан байх гэж ихэнх хүмүүс таамагладаг байжээ. Харин өрнөдийн домог мэддэг хүмүүс энэ чулууг Нуменороос авчирч, Исилдур өөрөө энд газар ухан суурилуулсан гэдэг ажээ. Хөндийн оршин суугчид энэ чулуунаас айгаад ойртдог ч үгүй, ойр хавьд хүн амьтан байдаг ч үгүй аж. Муу жил энэ чулууны эргэн тойронд үхээрийн сүгнүүд цугларч, хий үзэгдлээр дүүрдэг гэцгээдэг ажээ.

Дайчид чулууны дэргэд ирж зогсов. Эргэн тойрон нам гүм, түнэр харанхуй шөнө байв. Арагорн Элроироос мөнгөн бүрээг авч, хүнгэнэтэл үлээхэд алс холын агуйн гүнээс хариу цууриалахыг бүгдээрээ сонсов. Өөр юу ч сонсогдоогүй боловч, уул руу олон дайчид нөмрөн ирж, жихүүн салхи үлээхийг тэд мэдрэв.

Арагорн чулуунд тулж очоод, хүнгэнэсэн чанга дуугаар:

- Тангаргаасаа няцагсад та нар яах гэж ирэв? – хэмээн асуутал тэртээ холоос мэт нэгэн дуу хоолой:

- Тангаргаа биелүүлж, амар тайвныг олох гэж ирлээ – гэж хариуллаа. Тэгэхэд нь Арагорн:

- Та нарын цаг боллоо! Та нар миний хойноос Андуины Пеларгир хүр, тэр хязгаарыг Сауроны хар хүчнээс ангижруулсан цагт би та нараас хараалыг салгаж, та нар амар тайвнаа үүрд олно. Яагаад гэвэл Элессар би бол Гондорын агуу их ван Исилдурын удам залгамжлагч байна - гэлээ.

Тэгээд тэр Гальбарадад Уудам хөндийгөөс авч ирсэн тугаа задалж мандуул хэмээн тушаав.

Том хар туг салхинд дэрвэн мандав. Түүн дээр ямар бичээс байгаа нь харанхуйд үл харагдана. Дайчид чулууны дэргэд морьдоо амраан хонов. Хий үзэгдлүүдийн анир чимээгүй хүрээлэлд бараг хэн ч унтсангүй.

Үүр дөнгөж хаяарахад Арагорн дайчдаа алсын замд дахин удирдав. Энэ хүнд бэрх замыг ганцхан тэр л туулж чадах бөгөөд түүний хэлбэрэлтгүй эр зориг бусад дайчдыг зоригжуулан хүч оруулж байлаа. Ийм бэрх замыг түүнээс өөр хэн ч тэсч туулахгүй байсан ч түүнтэй хамт умардын дунадан баатар вангууд, гном Гимли, эльф Леголас нар туулж чадлаа. Тэд Тарлангийн даваагаар давж, Ламедонд хүрэв. Тэдний араас үл үзэгдэх арми довтолгож байлаа. Үхдлүүдийн арми довтолж байгаа тухай аймшигт мэдээ тарж, тэднийг Кирилийн Калембельд хүрч очиход Пиннат-Гелин уулын зүгээс цусан улаан туяа татаж, хотод амьд амьтан нэг ч байсангүй, Кирилийн гарам дээр ч хамгаалалт байсангүй, ихэнх нь дайнд явж, үлдсэн нь үхдлүүдийн арми ирж яваа чимээгээр уул өөд дүрвэжээ. Саарал бүлэг өглөө болохоос өмнө довтолгон одож, үхдлүүдийн арми араас нь уулгалж байв.

Бүлэг 3

Дайчдын цугларалт

Бүх зам аймшигт хар үүл бөөгнөрч байгаа, удахгүй болох гэж буй дайны голомт дорнод хязгаарт уулзаж байлаа. Пин Гондорын нийслэлийн их хаалганы өмнө зогсч, Дол-Амротын эзний алтлаг тугийг харцаараа үдэж байхад Ристаний эзний дайчид Хориглолт руу бууж байлаа.

Нар жаргах тийшээ хандаж байв. Морьт баатруудын өмнүүр урт урт сүүдрүүд бууж, харанхуй уулсыг бүрхсэн өтгөн ойг бүрхэж байв. Холын замд ядарсан эзэн захирагч мориныхоо жолоог сул тавин гэлдэрч байв. Эзэн захирагч бүтэн өдөр огт амралгүй давхисан учир удаан явж байлаа. Удалгүй жим нам гүмхэн ой дундуур оров. Тэгээд улам л доошилж, тахирлаж муруйн уруудсаар байв. Хавцлын ёроолд хүрэх үед нар жаргаж, хажуугийн хүрхрээний хүржигнэх чимээ, үдшийн бүрий тэднийг нөмрөв.

Өдрийн турш тэртээ дор харагдаад байсан тэр хүрхрээ одоо яг тэдний дэргэд хадан хавцлаас үсрэн гарах гэж байгаа юм шиг догшин сүрлэг оволзож байна. Морьт дайчид голын эргээр хатируулж байтал өмнөөс нь Дунхергийн хөндий гэнэт цэлсхийгэл гараад ирэв. Цасан голын хүчит урсгал буцлах мэт тонгочин, хадан эргээ хөөсөөр булсаар Эдорасын ногоон толгод, тэгш тал руу уулгалж байлаа. Өргөн хөндийн баруун талд үүлэн дунд зүүрмэглэх аварга хүчирхэг Старкгорн сүндэрлэж, мөнх цасанд хучигдсан иржгэр оргил нь үүлнээс дээш цухуйж, зүүн талдаа хар хөх сүүдэр хөврүүлэн унагаж харагдав.

Мерри урт замын туршид бишгүйдээ нэг сонссон, урьд өмнө үзээгүй энэ хязгаарыг гайхан харж явав. Тэнгэрийн бараа огт харагдахгүй, дээш хичнээн хараад ч нэмэргүй, зөвхөн сүрлэг хадан хясаа, мананд хучигдсан аймаар хавцлууд л үзэгдэнэ.

Тэр усны шуугиан, моддын бүдэгхэн шивнээн, унаж буй чулууны чимээг сонсож байвч энэ бүх чимээ мөдхөн алга болохыг мэдэрч байх мэт. Энэ уулс түүнд таалагдаж, Дундад газарт үзэж өнгөрүүлсэн бүхэн дурсамж болон улирч, гэртээ хариад тавлаг өрөөндөө, ил галынхаа дэргэд суухыг юу юунаас илүү хүсч байлаа.

Тэр их ядарчээ, тэд удаан урагшилж байгаа ч гэсэн бараг амсхийлгүй явсаар байв. Гурван урт өдөр тэд өндөр даваа, урт хөндийгөөр өгсч уруудаж, тоомшгүй олон гол горхийг гаталжээ. Зам өргөсөөд ирэхэд тэр эзэн захирагчтай зэрэгцэн явж байв. Өндөр цагаан морьтой Ристаний эзэн захирагч, сахлаг үст саарал пони унасан хоббит хоёр зэрэгцэн явахыг хараад морьт дайчид шоолонгуй инээмсэглэхийг тэр хоёр анзаарсангүй. Теодентой хэзээ язааны андууд шиг хууч хөөрч, Мерри өөрийнхөө тухай, хоббитаны домгуудын тухай ярьж, Мустангрим орон, Ристанийн баатар вангуудын гавьяаны тухай эзэн захирагчийн яриаг сонсч явлаа. Гэхдээ уулын нарийхан замд голдуу түүний араас дагаж, хэнтэй нь ч үг солилгүй ард яваа ристаничуудын удаан, уянгалаг яриаг сонсч явав. Тэгсээр олон үгийн утгыг ойлгодог болсон ч тэдний яриа дэндүү удаан хэмнэлтэй, уянгалаг аястай учир ярианы утга санааг эвлүүлэн ойлгож чадахгүй байв. Заримдаа хэн нэг нь дуу аялахад юун тухай дуу болохыг нь

ойлгоогүй ч гэсэн түүний зүрх урагдах шиг болж байв.

Гэлээ ч гэсэн тэр маш их ганцаардаж байсан бөгөөд ялангуяа одоо орой болж байгаа энэ үед бүр ч ихээр ганцаардаж байгаагаа мэдэн, ойлгомжгүй энэ ертөнц дээр яг одоо Пин, Арагорн, Леголас, Гимли хаана яваа бол доо гэж бодов. Гэтэл гэнэт түүний толгойд Сэм, Фродо хоёр минь хаана яваа бол? гэсэн бодол орж ирэхэд тэр “Би тэр хоёрыгоо бүр мартчихсан байна шүү дээ. Тэр хоёр маань бидний хамгийн гол хүмүүс шүү дээ, би тэр хоёрыг хамгаалах гэж нутгаасаа гарсан атал одоо тэр хоёр олон зуун бээрийн цаана яваа, амьд мэнд л яваа бол яамайдаа” гэж бодов. Ингэж бодонгуут түүний бие айсандаа агзасхийв.

- Энэ Нуувч байна! - гэж Эомер хэлээд – Бидний зам төгсгөл рүүгээ ойртлоо гэв.

Морьд зогслоо. Тэртээ дээр байгаа цонх шиг нарийхан хавцлын завсраар хөндий рүү орох зам харагдана. Доор, голын эрэгт жижигхэн гал нэг улалзаж, нэг бүүдгэрч харагдана.

- Тийм ээ, бидний замын төгсгөл ойрхон байна. Энэ бол шинэ замын эхлэл. Өчигдөр шөнө тэргэл сартай байсан, маргааш өглөө би Эдораст дайчдын цугларалтад очно – гэж Теоден хэлэв.

- Миний зөвлөгөөг авна уу, дараа нь энд эргэж ир, ялалт ялагдал хоёрын нэгийг энд хүлээ – гэж Эомер аяархан хэлэв.

- Үгүй шүү, - гэж Теоден мушилзаад - Үгүй, хүү минь, хэрэв би чамайг хүү минь гэж нэрлэвэл Өмхий Амт шиг зөвлөгч болохгүй! – гэснээ эмээл дээрээ өндийж, ард нь харанхуйд алдарч буй дайчдынхаа эгнээ рүү харж: - Би та нарыг дайн тулаанд дагуулж оролгүй олон он өнгөрчээ. Гэвч одоо би сууринаасаа сугарлаа. Хэрэв биднийг дайсан ялах юм бол би үүргээ эцэст нь хүртэл биелүүлээд үхэхэд гомдох юм алга. Хэрэв бид ялах юм бол бид ууланд нуугдаад яах билээ? Гэвч энэ бол дараачийн ажил. Харин одоо би нуувчид хононо. Ядаж нэг шөнө тайван унтацгаая. Явцгаая! – гэж хүнгэнүүлэв.

Тэднийг доош буухад бараг харанхуй болсон байв. Хөндийн баруун хязгаараар Цасан гол урсч, зам тэднийг гарам дээр авчрав. Гарам дээр хамгаалалт гарсан байлаа. Дайчид харанхуй хавцлаас гүйлдэн гарч, тэднийг хараад:

- Эзэн захирагч Теоден! Эзэн захирагч Теоден! Ристани эзэн захирагч эргэж ирлээ! – хэмээн хашгиралдав.

Эвэр бүрээнүүд хөндий даяар уянгалан цууриалав. Голын цаана дэнлүүнүүд аслаа.

Гэнэт өндөрлөг дээрээс олон бүрээ зэрэг нижигнэв. Бүрээнүүд нэгэн удирдагчийн дохиогоор дуугарч байгаа юм шиг сүрлэг найрал болж, хадан уулс тэр чигээрээ доргив.

Мустангримын эзэн захирагч дайснаа дараад өндөр уулын нуувч Дунхергдээ ингэж эргэж ирлээ. Ристани сүүлийн мянгат цугларч, эзэн захирагч ирж байгааг сонсоод захирагч нар нь Гэндальфын зөвлөсний дагуу түүнийг гарам дээр тосч уулзлаа. Нутгийн захирагч Дунгир тэдний түрүүнд ирэв.

- Эзэнтэн минь, гурав хоногийн өмнө үүрээр Эдораст аянга давхин ирж, Гэндальф чиний ялалтын тухай мэдээг авчран биднийг үгээр өгүүлшгүй баярлуулсан. Тэгээд таны өмнөөс дайчдын цугларалтыг яаравчлуулсан. Дараа нь далавчит хий үзэгдэл нөмрөн орж ирсэн.

- Далавчит хий үзэгдэл гэнэ ээ? - хэмээн Теоден асуугаад – Бид ч гэсэн тэрнийг харсан, гэхдээ шөнө дунд Гэндальф бидэнтэй хамт байхад.

- Та нар тэрнийг харсан ч байж болно, үгүй ч байж магадгүй. Тэр мөн үү, биш үү мэдэхгүй, гэхдээ шувуун мангас мэт харанхуй хар сүүдэр тэр өглөө Эдорасын дээгүүр гэнэт нөмөрч хэн бүхнийг айлгасан. Тэр Медусельдийн дээрээс доошилж, бараг ганжирт хүрээд амьд амьтны зүрхийг мөс болгемоор аймшигтай хашгирсан. Тэгээд Гэндальф биднийг талд цугларч таныг уулын Нуувчид биш, энд тосч авахыг зөвлөсөн юм. Бас туйлын чухал хэрэгцээ гараагүй л бол гал асаах, бамбарын гэрэл гаргахыг хориглосон, бид түүний зөвлөмжид таны зарлиг сонсогдож байсан учир ёсчлон биелүүлж байна. Энэ тал дээгүүр тэр мангас дахиж үзэгдээгүй – гэж Дунгир илтгэв.

- Та нар зөв сэтгэсэн байна - гэж Теоден хэлээд – Одоо би нуувч руу явна, унтахынхаа өмнө жанжингууд болон захирагч нартай уулзана. Тэднийг аль болохоор түргэн цуглуул! – гэж тушаав.

Зам одоо шууд зүүн зүг рүү, өргөнөөрөө хагас бээр хүрэхгүй хөндийгөөр өгсөв. Эргэн тойронд тариан талбай үзэгдэж, хөндийн цаад хязгаарт нэгэн цагт дундуур нь гол урсч байсан уулыг Мерри харав.

Тал хөндий хүмүүсээр дүүрэн байлаа. Тэд замын хоёр талд бөөгнөрч, эзэн захирагч болон өрнөдийн дайчдыг баярын мэндчилгээгээр угтав. Цаад талд нь асар майхнуудын эгнээ жигдрэн, түүний цаана морьдын жагсаал хөвөрч, үзүүрээр нь нийлүүлэн босгосон жаднууд өтгөн шугуй мэт үзэгдэв. Дайчдын хуаран үдшийн бүрэнхийд умбан, уулнаас шөнийн зэврүүн салхи үлээж байсан боловч түүдэг гал, дэнлүүний аль нь ч үл үзэгдэнэ. Урт цувтай харуулууд хуаранг тойрч, зөрөлдөн алхаж байлаа.

Энд хичнээн дайчид цугларсан бол? - гэж Мерри бодлоо. Улам өтгөрч байгаа харанхуйд тэдний тоог нүдээр багцаалах боломжгүй, ямар ч гэсэн олон мянган дайчид байгаа нь мэдэгдэж байв. Түүнийг ийш тийшээ хараачилж байх хойгуур эзэн захирагчийн түмт хөндийн зүүн хязгаар дахь асар том хясааны дэргэд ирсэн байв. Зам уул өөд огцом өгсч, Мерри дээшээ гайхсан харцаа өргөв. Тийм зам тэр урьд нь харж байсангүй. Хүмүүс энэ замыг аль дивангарт тавьсан бололтой. Зам могой мэт мушгирсаар эгц хясаанд тулжээ. Шат мэт эгц тэр замыг морьд арайхийн туулж байсан ч энэ замаар ачааны цуваа ч өгсч болохоор ажээ. Харин агаараас л дайрдаггүй юм бол ямар ч дайсан хамгаалагчдыг бүслэх боломжгүй байв. Замын эргэлт болгон дээр бүдүүн гараа цүндгэр гэдсэн дээрээ тавьж, завилан суусан хүн чулуунууд байх бөгөөд он цагийн уртад нүүрний төрх нь элэгдэн алга болж, зөвхөн нүд гаргасан нүх нь л дайчдын цувааг харж байх мэт. Пуккол хэмээх тэр хүн чулуунууд ямар нэг ид шидгүй, хэн ч тэднээс айдаггүй тул дайчид тэдэн рүү харах ч үгүй явна. Ганц Мерри л харанхуй дундаас сүглийж байгаа тэдэн рүү гайхсан, бараг өрөвдсөн нүдээр харж явав.

Дараа нь тэр эргэж харахад тэд маш өндөрт гарсан байх бөгөөд тэртээ доор дайчид

төгсгөлгүй урт цуваагаар ирж, хуарангаар таран байрлаж байгааг харанхуйд ч гэсэн харж болохоор байлаа. Зөвхөн эзэн захирагч л дагуулууд, хамгаалагчидтайгаа Нуувч руу өгсч байгаа ажээ.

Эцэст нь тэд уулын орой дээр гарч ирэхэд цаана нь өргөн хөндий цэлийж байв. Фириэнфельд гэдэг агаад уудам бөгөөд үзэсгэлэнтэй өвс ургамал тэгш, дундуур нь Цасан гол ширүүхэн урсч байна. Дайчид Ирензагийн нуруу руу зүглэхэд өмнө талд нь Двиморберг буюу эргэн тойрон нарсан ойгоор хүрээлэгдсэн хий үзэгдлийн уул сүндэрлэн угтав. Хөндий дундуур хоёр эгнээ эв хавгүй чулуун хэрэм байх бөгөөд зам тэр дундуур ороод нарсан ойд алдарчээ. Хэн нэгэн тэр замаар зориглон явбал Димхолтын харанхуй ой руу орж, аймшгийн багана болон хориот хаалгыг үзэх билээ.

Эртний хүмүүсийн босгосон дүнсгэр Дунхерг ийм л байлаа. Энэ хотыг барьсан омгийн талаар үлгэр домог, дуу шүлэгт юу ч үлдсэнгүй. Эртний тэр хүмүүс чухам юу барьсан нь ч тодорхойгүй. Хот юм уу, нууц сүм барьсан юм уу, эсвэл хаагийн бунхан барьсан юм уу, мэдэх аргагүй. Баруун эрэгт хөлөг онгоцууд хөвөн ирж, дунаданчууд Гондорыг үндэслэн байгуулахаас хамаагүй өмнөх харанхуй эринд энэ хотыг барьсан ба тэр ард түмэн аль эрт мөхөж, зөвхөн пукколууд л замын эргэлтийн хадан дээрээ зөрүүдлэн суусаар байлаа..

Мерри хадан уулын хөрөөний шүд шиг ирмэгийг харав. Тэр шүднүүд харлаж, салхинд элэгдэн мөлийж, зарим нь хазайж, зарим нь онгойтол унаж, зарим нь хагарч элтэрч яахын аргагүй хөгшин гэдэг нь илт харагдаж байв. Энэ шүднүүд энд яах гэж арзайж байдаг юм бол доо хөөрхий гэж тэр бодонгуутаа эзэн захирагч арай эдний дундуур гүн харанхуй руу орохгүй байлгүй дээ гэж найдав. Дараа нь тэр замын хоёр талаар үй олон асар, майхан, хашаа саравч байхыг үзэв. Тэдгээр нь ойгоос зайдуу, бүр хясааны ирмэгт тулжээ. Хуарингийн ихэнх хэсэг баруун талд, Фириэнфельдийн өргөссөн хэсэгт байрласан бөгөөд зүүн талд цөөхөн майхан дотор нэг сүрлэг том асар байв. Тэр асраас нэгэн морьтон тэднийг угтан гарч ирэхэд тэд замаас гарлаа.

Морьтон ойртож ирэхэд Мерри сонирхон харвал эмэгтэй хүн байлаа. Долгиотсон урт үс нь харанхуйд гялалзаж, хуяг дуулга, илд бамбай нь тодорч харагдав.

- Сайн явж ирэв үү, Мустангримын эзэн захирагч минь, чамайг эргэж ирсэнд үнэн зүрхнээсээ баярлаж байна! – гэж тэр хэллээ.

- Дуу хоолой чинь нэг л гунигтай байх чинь Эовин, ямар нэг юманд санаа зовоо юу? – гэж Эзэн захирагч асуув.

- Үгүй дээ, бүх юм ёсоороо явж байна – гэж тэр аяархан хэлэхэд нулимсаа арай ядан барьж байгаа юм шиг сонсдов. Ийм эршүүд эмэгтэй нулимс гаргадаггүй л баймаар - гэж Мерри бодов.

- Бүх юм ёсоороо л явж байна. Хүмүүс гэв гэнэт орон гэрээ орхиж, хол газар явах мэдээж хэцүү л байсан. Манай энэ ногоон талд дайн байлдаан бололгүй олон он өнгөрсөн болохоор хүмүүс сандарч байсан, гэвч зарлигийг дагахгүй гэсэн хүн байгаагүй. Дайчид цугларсан байгааг ч харж байна. Чиний амрах байрыг ч бэлдсэн. Би чиний ялалтын мэдээг авсан учир

чамайг яаж угтахаа мэдэлгүй яахав.

- Тэгэхлээр Арагорн ирчихсэн хэрэг! Тэр одоо энд байгаа юу? – гэж Эомэр асуухад:

- Мэдэхгүй ээ, тэр энд байхгүй - гэж Эовин хэлээд цааш эргэж, зүүн, өмнө талын харанхуй оргилууд руу харав.

- Тэр хаана байна? - гэж Эомер асуулаа.

- Мэдэхгүй ээ, уржигдар шөнө давхиж ирээд өчигдөр өглөө үүрээр яваад өгсөн, одоо хаана байгааг би яаж мэдэхэв дээ.

- Чи нэг юманд их санаа зовсон байна даа, охин минь, юунд санаа зовов? Тэр замын тухай ярьсан уу? – гээд Теоден чулуун хавцлын зам руу зааж: - Үхдлүүдийн замын тухай ярьсан уу?

- Тийм ээ, эзэн минь, тэр эргэж гарах гарцгүй үхлийн харанхуй руу явсан. Би хориглоод дийлээгүй. Одоо хаана байгааг би мэдэхгүй.

- Тэгвэл бидний зам салж дээ. Тэр үхлийн харанхуйд алга болж. Бид тэрэнгүйгээр, ялах найдваргүйгээр тулалдах болж дээ – гэж Эомер хэлэв.

Тэд дуу шуугүй дээшээ өвсөрхөг нуга өөд өгсөж, Эзэн захирагчийн асарт ирэв. Бүх хүнд бүх зүйлийг бэлджээ. Мерриг онцгойлон үзэж, том асрын дэргэд жижигхэн майхан босгосон байв. Тэр майхандаа ороод гав ганцаараа амарч, хажуугаар нь хүмүүс хөлхөлдөн, зөвлөгөөнд ирэгсэд эзэн захирагчийн асарт орцгооно. Улам харанхуй болж, баруун уулсын оргилууд одон титмээ гялалзуулан, зүүн зүгт тас харанхуй болов. Хөрөөний шүд шиг ирмэгүүд үзэгдэхээ больсон ч цаана нь Двиморберг харлан ханхайж байна.

- Үхдлүүдийн зам гэдэг нь бас юу юм бол доо? - хэмээн Мерри өөрөө өөртэйгөө ярьж – Юун үхдлүүдийн зам? Манай отрядаас ганц би л хийх ажилгүй зүгээр сууж байх шив дээ. Хувь заяа бүгдийг нь тараачихлаа. Гэндальф, Пин хоёр дорно зүгт байлдахаар явсан, Сэм, Фродо хоёр Мордор руу, Арагорн, Леголас, Гимли гурав тэр үхдлүүдийн зам руу явсан юм байна. Миний ээлж ч мөдхөн ирнэ биз. Эд нар юу гэж зөвлөлдөж байгааг мэддэгсэн бол, эзэн захирагч юу гэж төлөвлөж байгааг мэдэхсэн. Би тэрэнтэй холбогдсон, тэр хаашаа – би тийшээ явна шүү дээ.

Санаанд нь олигтой бодол орж ирсэнгүй, ядаж байхад их өлсч байгаагаа гэнэт мэдээд, энд ганцаараа өлсгөлөн байна уу, үгүй юу гэдгийг мэдэхээр майхнаас гарав. Яг тэгтэл бүрээ цууриалж, эзэн захирагчийн дагуул түүнийг оройн зоогонд урив.

Асрын хойморт хээ угалзтай хөшигнүүдийн цаана ангийн арьсан дэвсгэр дээр, намхан ширээний ард эзэн захирагч Теоден, Эомер, Эовин, энэ хязгаарын захирагч Дунгир нар суужээ. Мерри эзэн захирагчийн ард өөрийнхөө суудлыг эзлэв. Гүн бодолд дарагдан сууж байсан эзэн захирагч түүн рүү инээмсэглэн эргэж хараад:

- Наашаа суу, эрхэм ноён Мериадок! Чи зогсч байх эвгүй юм. Бид миний мэдлийн газар дээр

байгаа цагт чи миний дэргэд сууж, миний сэтгэлийг яриагаараа амрааж байх болно - гэлээ.

Хоббитыг эзэн захирагчийн зүүн талд суулгасан боловч яриа хөөрөө өрнүүлсэнгүй. Ганц нэгхэн үг солилцон чимээгүй хооллоцгоож байв. Эцэст нь Мерри зориглож, хэлний үзүүрт эргэлдээд байсан асуултаа асуув:

- Эзэн захирагч минь, би Үхдлүүдийн зам гэдэг үг хоёр удаа сонслоо. Тэр чинь юун зам юм бэ? Тэнэмэл ... үгүй ээ Арагорн тэр замаар хаашаа явсан юм бэ?

Эзэн захирагч зөвхөн санаа алдаж, Мерри хариу хэлэхийг нь хүлээж байтал Эомер:

- Тэр хаашаа явсныг бид мэдэхгүй байна. Харин Үхдлүүдийн замын тухайд гэвэл... чи өөрөө сая тэр замаар явж ирсэн. Миний үгнээс аюул занал битгий хай! Зүгээр л бидний явж байгаад салсан өгсүүр зам Димхолтоор дайраад хориотой хаалганд хүрдэг юм. Тэрний цаана юу байдгийг хэн ч мэдэхгүй - гэв.

- Тийм ээ, тэр тухай хэн ч мэддэггүй юм - хэмээн Теоден батлаад – Зөвхөн бараг мартагдсан эртний домогт л энэ бүдэг дурсамж хадгалагдаж үлдсэн. Манай омог – Эорлын омогт эрт балар цагаас эцэг нь хүүдээ тэр домгийг ярьж өгдөг байсан юм, хэрэв эртний тэр домогт үнэн өгүүлдэг бол Двиморбергийн доорх нууц замаар уулын гүн рүү орж болно. Брегогийн хүү Бальдороос хойш тэр хаалгаар хэн ч зориглож ороогүй өдийг хүрсэн. Брего Медусельдыг барьсанд зориулж их найр хийсэн, Бальдор дарсанд халаад, сүг сүүдрийн уулны нууцыг тайлна гэж андгайлжээ. Тэгээд тэр хүмүүсийн нүднээс үүрд алга болж, эзэн хааны алтан ганжирт өргөөн дэх хаан ширээ залгамжлагчгүй болсон.

Балар харанхуй эриний талийгаач нар тэр нууц шилтгээнд амьд амьтдыг оруулахгүй чандлан сахидаг, харин өөрсдөө бол гадагш гарч, замаар сүг сүүдэр урууддаг гэж ардын домог ярианд өгүүлдэг. Тэгэхэд нь нуувчийн оршин суугчид үүд хаалгаа түгжиж, цонхондоо хөшиг татдаг юм. Гэхдээ сүг сүүдрүүд ховорхон гарч ирдэг, зөвхөн дайн дажинтай үед л үзэгддэг юм.

- Нуувчнаас ирсэн мэдээгээр бол - гэж Эовин аяархан өгүүлэв: - саяхан саргүй шөнөөр ер бусын хуяг дуулгатай олон дайчид уулан дээр гарсан гэнэ. Хаанаас тэд гараад ирснийг хэн ч мэдэхгүй байна. Тэр дайчид чулуун хэрмийн дундуур Двиморберг руу давхин оджээ.

- Арагорн тийшээ яах гэж явсан юм бэ? Бүр юу ч мэдэгдээгүй юу? – гэж Мерри шалгаав.

- Бидний мэдэхгүй байгаа юмыг түүний найз чи л бидэнд хэлэхгүй юм бол чамд хариу өгөх амьд амьтан алга даа - гэж Эомер хэлэв.

- Би түүнийг өргөөнд анх хараад их гайхсан. Тэр өтөлж, зан нь ширүүн болсон байна лээ. Урьд би түүнийг тийм байхыг нь үзээгүй. Нэг юм багтай шийдсэн нь илт байсан. Тэр булшны дуу хоолойг сонсч байх шиг надад санагдсан – гэж Эовен өгүүлэв.

- Сонсогдсон ч байж магадгүй, тэр бид хоёр дахиад уулзахгүй байх гэж зүрх минь мэдрээд байна. Гэлээ ч гэсэн заяаны эзэн хаан түүнд их хувь заяаг бэлдсэн байх ёстой. Сэтгэлээ бүү чилээ, охин минь, чи манай зочинд их санаа зовниж байгааг би харж байна. Санаа бүү зовни,

яагаад гэвэл эорлингууд умар зүгээс ирж, ирээдүйн цайзаа барихаар Цасан голын эх өөд өгсөхөд, Брего хүү Бальдортайгаа Димхолтын завсраар явж Нуувчийн цаана гараад Хар хаалганд хүрсэн гэж ярьдаг юм. Тэр хаалганы дэргэд нар салхинд элэгдсэн чулуун хөшөө шиг балар эртний нэг өвгөн сууж байжээ. Өндөр чацархаг, эзэн хаан дүртэй өвгөн үг ч дуугаралгүй, хөдлөх ч үгүй суугаад байжээ. Брего, Бальдор хоёр түүнийг хүн чулуу юм байх гэж бодоод хажуугаар нь өнгөртөл газар дороос дуугарч байгаа юм шиг нийтийн хэлээр - Зам хаалттай – гэж өвгөн хэлжээ.

Тэр хоёр зогсоод өвгөн рүү хартал тэр дөнгөж амьд байгаа боловч өөдөөс нь харсангүй.

- Зам хаалттай. Аль эрт үхсэн сүг сүүдрүүд тэр хаалгыг тэнд гаргасан бөгөөд цаг нь болтол сүг сүүдрүүд манаж байх болно. Зам хаалттай - гэж давтан хэлжээ.

- Цаг нь хэзээ болох юм бэ? – Бальдор асуусан боловч өвгөн хариу хэлсэнгүй, унаад өгчээ. Тэр цагаас хойш бид уулын гүний манаач сүг сүүдрүүдийн талаар юу ч сонсоогүй. Гэвч, одоо хугацаа нь болж, Арагорнд зам нээгдэж болох юм.

- Хаалгаар оролгүйгээр зам нээгдсэн эсэхийг яаж мэдэх юм бэ? - гэж Эомер хэлээд - Би л лав тийшээ орохгүй. Мордорын бүх цэрэгт ганцаараа бүслэгдчихээд хаашаа ч гарах газаргүй байсан ч орохгүй. Өнөөгийн энэ зэвүүн цагт баатар вангуудын дээд нь болсон түүнийг тийш нь юу дууддаг байна аа! Эргэн тойронд хар дайснууд язганаж байхад тэрнийг газар дороос хайж юугаа хийнэ? Дайн эхэлж байдаг, гэтэл тэр... – гээд Эомер дуугүй болов. Гадаа хүмүүс шуугилдаж, хэн нэгэн Теодены нэрийг хэлж, харуул түүнийг асууж шалгааж байлаа.

Төдөлгүй харуулын дарга асрын хөшгийг сөхөөд:

- Эзэн минь Гондороос элч иржээ. Эзэн захирагч руу нэн даруй оруул гэж шаардаж байна.

- Орог орог! - гэж Теоден хэлэв.

Өндөр чацархаг баатар орж ирэхэд Мерри арай л хашгирчихсангүй: Боромир амьдаараа ороод ирэх шиг санагджээ. Сайтар харвал урьд өмнө үзээгүй хүн боловч Боромиртай дэндүү адилхан ажээ. Тэрбээр нарийн ширхэгт торон хөө хуягны дээгүүр морьт баатрын хар ногоон цув өмссөн байх бөгөөд дуулганых нь титэмнээс мөнгөн од гялалзана. Гартаа мөлийж, харласан ган зэвтэй, хар өдтэй сум барьсан байв.

Тэр өвдөг сөгдөөд, барьсан сумаа эзэн захирагчид өгөв.

- Мустангримын эзэн захирагч, манай эртний анд бөгөөд үнэнч хамтрагч чамд мэндийн ерөөл өргөө! – гэж тэр хэлээд – Денэторын элч Хиргон би дайны энэ тэмдгийг чамд гардуулж байна. Гондорт агуу их аюул тулгарлаа. Мустангримчууд бидэнд туслахаас хэзээ ч татгалзаж байгаагүй, энэ удаа ч гэсэн Денэтор чамайг бүх хүчээ цуглуулаад аль болохоор даруйхан ирээч гэж гуйлаа. Тэгэхгүй бол Гондор тэсэхгүй!

- Хүрэн сум! – гэж Теоден хэлээд сумыг чичирсэн гараараа авахдаа; - Хүлээж л байсан мэдээ боловч их аюулын мэдээ байна. Миний үед хүрэн сумыг Ристанид нэг ч удаа илгээж

байгаагүй юм! Хамаг найдвар нь бидэнд байна гэж үү? Денэтор юу гэж бодож байна. Бидний хүчийг их гэж бодож байна уу, бид хурдан амжиж очно гэж найдаж байна уу?

- Энэ талаар та надаас илүү мэднэ дээ эзэн минь, гэвч Гондор өнөө маргаашгүй бүслэгдэнэ. Хэрэв та нар хүчирхэг бүслэлтийг сэтэлж чадахгүй бол Ристаний дайчид ханан доогуур хэвтсэнээс ханан дээр зогссон нь дээр гэж эзэн хаан Денэтор танд дамжуулахыг тушаасан!

- Бид тал газарт морьтойгоо тулалдаж сурсан, манай ардууд уул нуруу, тал хөндийгөөр тарж суурьшсан, тиймээс морьт дайчдыг хоромхон зуурт цуглуулах боломжгүй гэдгийг тэр мэдэхгүй гэж үү дээ? Минас-Тиритийн эзэн захирагч ярьж байгаагаасаа ямагт илүүг мэддэг гэдэг үнэн үү, Хиргон? Яагаад гэвэл бид аль хэдийн цугларчихаад байгааг чи харж байна, чиний мэдээ биднийг бажгадуулсангүй. Саарал Гэндалф манайд ирсэн, бид дорно зүг агуу тулалдаанд мордох бэлтгэлээ хангасан.

- Энэ тухай эзэн захирагч мэдэж байгаа эсэхийг мэд гэж надад даалгаагүй, манай эзэн танд зарлиг дамжуулаагүй, эртний эв найрамдлынхаа нэрийн өмнөөс, эртнээс нааш биелүүлж ирсэн андгай тангаргаа бодож, өөрийнхөө газар нутаг, албат ард, эзэнт төрөө аврахын тулд чадах бүхнээ хийгээч гэж гуйсан. Дорнын олон хаад цэргээ Мордорын дэргэд авчирсан гэж бидэнд мэдээлж байна. Умард хязгаараас Дагорладын тал хүртэл дайны түймэр дүрэлзэж байна. Өмнөдөөс хордримчүүд ирж байна, манай тэнгисийн эргийн хамгаалалт тулаанд бэлэн, гэвч тэндээс бидэнд их тусламж ирэхгүй. Яарагтун эзэн минь! Минас-Тиритийн ханын дэргэд нийтийн хувь заяа шийдэгдэнэ, хэрэв бид дайсныг тэнд тогтоож чадахгүй бол, хар хүчний үер Ристаний тал нутгийг хамна, энэ ууланд ч гэсэн хэн ч хоргодож чадахгүй.

- Мэдээ гэж хэлэхээргүй ч гэсэн муу л мэдээ байна. Тэгэхлээр, Денэторт ингэж хэл. Хэрэв Ристанид аюул нүүрлээгүй байсан ч гэсэн бид тэртэй тэргүй та нарт туслахаар очих байсан. Гэвч урвагч Сарумантай байлдахад бид их хүчээ алдсан, бас умард болон зүүн хязгаараа хамгаалах хэрэгтэй, дайсан тал талаас ойртож байна гэж чи өөрөө хэллээ.

Хар эзэнд Минас-Тиритийг унагаах хүч ч бий, манай хойт талаас дайрч, Андуиныг гатлан Чулуун аваргуудын цаана гарах хүч ч хангалттай бий. Нэг үгээр хэлэхэд бид алгуурлахгүй. Гэхдээ хэтэрхий их болгоомжлохгүй. Маргааш өглөө дайчдын бэлтгэлийг шалгаад л шууд хөдөлнө. Бүх юм өнөөгийнхөөс өөр байсан бол би арван мянган морьт дайчдаараа дайсныг амдан тосох байлаа. Гэвч үүнээс цөөн дайчин илгээх байх гэж айж байна. Хана хэрмээ хамгаалалтгүй орхиж болохгүй шүү дээ. Гэвч ямар ч гэсэн зургаан мянга гаруй дайчин очно, энэ удаа эзэн хаан өөрөө цэргээ удирдан Гондорт очно, юу л болвол болог - гэж Денэторт хэл. Харин алсын замд морьд, хүмүүсээ сульдаахгүйн тулд маргааш өглөөнөөс долоо хоногийн дараа та нар умар зүгээсээ Эорлын хөвгүүдийн байлдааны уриаг сонсох болно.

- Долоо хоног! - гэж Хиргон уулга алдсанаа – За, чи илүү сайн мэдэж байгаа. Гэхдээ долоо хоногийн дараа та нар нурсан хэрмэн дээр л давхиж очих байх даа, гэвч ядаж орхууд болон хар царайтууд Цагаан цайзад найрлахыг саатуулна биз дээ.

- Ядаж найр хийхийг нь саатуулна аа, гэвч би дайны талбараас урт зам туулж, дөнгөж мориноос буугаад байна, их ч ядарлаа. Хуаранд хоноод яв. Амарч хоноход хүч сэлбэнэ, өглөө Ристаний армийг харахад хийморь чинь сэргэнэ. Өглөө оройноос цэцэн, шөнө бодоход бодол

саруулсана.

Ингэж хэлээд эзэн захирагч босоход бусад нь даган бослоо.

- Явж амар, сайхан амраарай. Эрхэм Мериадок таныг ч гэсэн энэ шөнө чөлөөлж байна. Харин өглөө үүр хаяармагц над дээр бэлэн байгаарай.

- Яг эхний дуудлагаар очно. Хэрэгтэй бол таныг дагаж үхдлүүдийн замаар ч явахад бэлэн - гэж Мерри хэлэхэд:

- Муу үгнээс болгоомжил! – гээд эзэн захирагч толгой сэгсэрч: - магадгүй ганц энэ зам ч үхдлүүдийн зам биш байж болно. Гэвч би одоохондоо чамайг тулалдаанд авч орох гээгүй байна. Сайхан нойрсоорой!

- Үгүй шүү, би эдний эргэж ирэхийг хүлээгээд энд үлдэхгүй! - хэмээн Мерри өөртөө баттай хэлээд – Яасан ч үлдэхгүй, яасан ч үгүй! – гэж өөртөө андгайлав. Тэгээд энэ үгээ янз янзаар давтан үглэсээр эцэст нь майхандаа ороод унтаад өгөв.

Түүнийг нэг дайчин мөрнөөс нь сэгсчин байж сэрээв.

- Сэрээрэй, сэрээрэй, ноён хоббит гуай! – гэж тэр дуудахад Мерри гүн нойрноосоо гэнэт сэрж, орон дотроо өндийж суув. “Ямар харанхуй байна аа”, - гэж тэр бодоод:

- Юу болоов? – гэж асуулаа.

- Эзэн захирагч таныг хүлээж байна.

- Нар гараагүй байна шүү дээ - хэмээн Мерри гайхав.

- Тийм ээ, ноён хоббит гуай, нар мандаагүй, өнөөдөр ерөөсөө мандахгүй хачин муухай харанхуй нөмөрсөн учир нар алга болчих шиг боллоо. Гэвч нар мандсан ч, мандаагүй ч цаг хугацаа явдгаараа явж байгаа. Түргэлж үз!

Мерри яаран хувцаслаад майхнаасаа шагайж харав. Бүрхэг хүрэн гэгээнд бүх юм тас хар харагдаж, хаана ч, ямар ч сүүдэр байхгүй, амьд амьтангүй мэт аниргүй нам гүм байлаа. Тэнгэр тэр чигээрээ харанхуй, зөвхөн тэртээ баруун зүгт махир мойног хуруунууд дундаас цухуйж байгаа тамхины оч мэт бөөн үүлний завсраар нарийхан зурвас гэгээ үзэгдэв. Дараа нь эргэн тойронд бараан царайт хүмүүс зогсоод тэнгэр өөд айсан, байдалтай харж, хоорондоо аяархан ярилцаж байхыг Мерри ажиглав. Тэр сэтгэлээр унаж, эзэн захирагчийн асар өөд алхлаа. Хиргон тэнд ороод ирчихсэн байна, хажууд нь түүнтэй адилхан, түүнээс арай намхан, өргөн цээжтэй бас нэг элч зогсч байна. Мерриг асарт ороход тэр элч эзэн захирагчид:

- Мордороос энэ харанхуй нөмөрлөө эзэн минь. Өчигдөр нар жаргах үеэр нөмөрсөн. Истфольдын толгод дээрээс би харсан, түнэр харанхуй дээш хөөрч, дараа нь намайг гүйцээд, тэнгэрийг бүрхэж, оддыг бөхөөсөн. Эндээс Изгарын уулс хүртэл бүх газар нэлэнхүйдээ харанхуй болсон, одоо улам өтгөрч байна. Дайн эхэлдгээ эхэлчихлээ – гэлээ.

Асарт чив чимээгүй болсноо эзэн захирагч:

- Тийм дээ, болох ёстой юмнаас булгаж болдоггүй. Тэгэхлээр тэр их дайн эхэллээ, энэ дайн олон амьтны амийг эргэлт буцалтгүй авч одно. За яахав, одоо ядаж нуугдах хэрэггүй боллоо. Тал дундуур шуудхан давхицгаая. Цугларалтыг одоо үзье. Хоцорсныг хүлээхгүй. Минас-Тиритэд ус, хүнсний нөөц хангалттай бий юу? Хурдан явахын тулд тун бага хүнс, ус авч явах хэрэгтэй.

- Нөөц манайд хичнээн л бол хичнээн бий. Аль болохоор багыг авч, аль болохоор хурдан давхицгаа! - гэж Хиргон хэлэв.

- Жанжингуудыг дууд, Эомер, аяны жагсаал зарла! – гэж Теоден захирав.

Эомер гарч одоход Нуувч даяар бүрээнүүд хүнгэнэж, тээр доороос хэдэн арван бүрээ хариу хүнгэнэв. Гэвч бүрээнүүдийн дуу Меррид өмнөх шигээ сүртэй чанга найрал санагдсангүй. Бөглүү, сөөнгө хоолой мэт бүрээнүүдийн цууриа амьсгаа давчдам харанхуйд тэгсгээд уусав.

Эзэн захирагч Меррид хандаж:

- Би дайнд мордлоо, эрхэм Мериадок минь, цагийн дараа замдаа гарна. Чи миний албанаас чөлөөлөгдлөө, гэвч миний халамжийг алдахгүй. Эндээ үлд, хүсвэл хатан хаан Эовинд үйлчил, тэр намайг орлож, энэ орныг захирна.

- Юу гэсэн үг вэ, эзэн минь, - хэмээн Мерри ээрэн хэлээд – Би илдэн дээрээ гараа тавьж, тангараг өргөсөн! Үгүй ээ, эзэн захирагч Теоден, би чиний албанаас чөлөөлөгдөхгүй. Тэгээд ч андууд минь бүгд тулалдахаар явсан, би энд зүгээр сууж үлдэхээсээ ичиж байна.

- Бид том, хурдан морьдоор давхина. Чи тийм морин дээр тогтохгүй, үүнд ганц эр зориг багадна.

- Тэгвэл намайг эмээл юм уу, дөрөөтэй бэхэлчихнэ биз, мориор давхиж болохгүй юм бол гүйчихье, даанч газар хол болохоор хоёр гурван долоо хоног хоцорч хүрэх байх даа.

- Тэгснээс би чамайг Цагаан дэлт дээр дүүрч давхисан нь дээр биз дээ – гэж Теоден жумалзаад – За за, надтай хамт Эдораст очиж, Медусельдийг үз, бид эхлээд тийшээ явна. Одоохондоо тийм ч айхтар давхихгүй. Жинхэнэ давхилт дараа нь тэгш тал дээр болно.

Тэгтэл Эовин орж ирэв.

- Явцгаая, Мериадок! Би чамд байлдааны өмсгөл, зэвсэг бэлдсэн, тааруулж үзье - гэж тэр хэлээд Мерриг дагуулж гарав.

- Арагорн надаас ганцхан л юм гуйсан, - гэж Эовин асруудын хоорондуур явах зуураа яриад – тэр чамд байлдааны хувцас, зэр зэвсэг бэлдэж өгөөрэй гэсэн юм. Миний бэлдсэн зүйлс чамд таалагдана гэж найдаж байна.

Тэрбээр Мерриг хамгаалалтынхны нэг майханд дагуулж ороход зэвсэг түгээгч тэндээс

жижигхэн дуулга, дугариг бамбай болон бусад зэр зэвсэг гаргаж өгөв.

- Чамд таарах жижиг хөө хуяг олдсонгүй - гэж Эовин хэлээд, - Одоо чамд хөө хуяг давгаж амжихгүй, гэхдээ энэ ширэн хүрэм, бүс, кинжаалыг ав. Илд чамд байгаа.

Мерри мэхийн ёслоход хатан хаан түүнд Гимлид өгсөн бамбайнаас жижиг, ногоон талд цагаан морь давхиж явааг дүрсэлсэн бамбай өглөө.

- За өмсгөлөө өмсч, зэвсгээ агс даа, чамд найдвартай үйлчлэх болтугай! Баяртай, Мериадок!
Бид дахиад уулзах ч юм бил үү.

Ристанийн дайчид өтгөрсөөр байгаа харанхуй дунд зүүн замын хажууд эгнэн жагсчээ. Тэдний зүрх түгшиж, олон дайчин айж балмагдсан байртай харагдав. Гэвч ристанийн дайчид сэтгэлийн хат ихтэй, эзэн хаандаа үнэнчээрээ алдартай билээ. Тэр ч байтугай Эдорасын хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшдийг байрлуулсан нуувчид элдэв үг яриа, уйлж дуулах сонсогдсонгүй. Хувь заяаны сорилтыг дуугүйхэн хүлээж авлаа.

Хоёр цаг дорхноо өнгөрч, Теоден харанхуйд мөнгөрөн цайрч харагдах цагаан мориндоо морджээ. Дуулган дороос мөрөн дээр нь буурал үс намиран буусан цагаан морьтон агуу сүрлэг харагдаж, дайчид аймшиггүй эрэлхэг бөгөөд мэргэн удирдагчаа хараад сэтгэл нь сэргэн, урам зориг нь бадрал.

Шуугиант голын хажуу дахь өргөн нугад яг таван мянган морьт дайчид бүрэн зэвсэгтэй эгнээ эгнээгээрээ жагсч, бас хөнгөн ачаа, нөөц морьтой хэдэн зуут эгнэжээ. Бүрээ хүнгэнэхэд эзэн захирагч баруун гараа дээш өргөн хөдлөх дохио өгч, Мустангримын арми чимээгүйхэн хөдөллөө. Эзэн захирагчийн бие хамгаалагч арванхоёр алдартай баатар цувааг тэргүүлж, араас нь Теоден, Эомер хоёр дөрөө харшуулан зэрэгцэв. Тэд дээр Нуувчид байхдаа Эовинтэй салах ёс хийсэн бөгөөд салалтын мөч хичнээн гунигтай байсан ч цөмөөрөө урагш яаран тэмүүлж байлаа. Дараа нь Гондорын элч нар болон Мерри, тэгээд дахин арванхоёр бие хамгаалагч явна. Тэд морьт дайчдын урт цувааны дэргэдүүр өнгөрөхөд тэдний царай ширүүн бөгөөд шийдвэр төгс байлаа. Жагсаалын цаад үзүүрт хүрч явтал морьт дайчдын нэг нь хоббит руу эгцлэн ширтэв. “Бүр хүүхдээрээ амьтан байна шүү дээ, намхан, туранхай” – гэж хоббит бодлоо. Хурц саарал нүдтэй нь харц тулгарахад гэнэт энэ царайд найдвар алга гэж бодоод бодлоосоо цочив. Саарал чулуун дундуур бургилан урсах Цасан голын дагуу, Ундерхерг ба Обернан суурингийн хажуугаар өнгөрөхөд, харанхуй хаалгануудаас эмэгтэйчүүдийн гашуудалт царай цухалзах бөгөөд дайчдаа дайн тулаанд үдэж эвэр бүрээгээ ч үлээсэнгүй, арфа хөгжмөө ч эгшиглүүлсэнгүй, өөрсдөө ч уянгат дуугаа дуулсангүй. Ристанчуудын олон үеийнхэн дуу шүлэгтээ мөнхрүүлсэн агуу их аян дайны тухай ингэж хэлсэн юм:

Сүүдэрт Дунхергийн бүрхэг өглөөгүүр

Сүүлчийн мянгатаа Тэнгэлийн хүү гаргалаа.

Эдорастанд очиход хаанлаг өргөөд

Эртний алтан ганжиртайгаа

Энгүй харанхуйд хучигдсан байлаа.

Өвөг дээдсийнхээ нутаг дээр тэр

Өөрийн ард түмнээ орхилоо.

Эрх чөлөөт эгэл олон түмэн,

Эцгийн гал голомтоо үлдээлээ.

Өнийн сайн цагт найрлаж асан

Өргөө их шилтгээн юугаан,

Өндөр их хаан ширээгээ үлдээлээ.

Аян дайн мордсон Эзэн захирагчийг

Аймигийн харанхуй араас нь хөөж

Алс замын үзүүрт үхэл тосч байлаа.

Эвдэж үл болох эртний андгайгаа

Эзэн захирагч үнэнчээр биелүүлсэн юм.

Теоден цааш давхлаа

Таван өдөр таван шөнө давхлаа...

Эзэн захирагч үд дунд Эдораст орж ирэхэд Медусельд харанхуйд хучигдсан байв. Дайчдын цуваа тэнд удаан саатсангүй, цугларалтаас хожимдсон жар гаруй морьт дайчид араас нь нэхэн гүйцэв. Хооллож, ундалсаны дараа эзэн захирагч замдаа гарахад бэлдэх тушаал өгөөд дагуултайгаа салах ёс хийв. Гэвч Мерри хамт явья гэж дахин нэг гуйх гээд үзэв.

- Би чамд тайлбарласан шүү дээ. Ийм аяныг Стибба пони, өөрөө бодоод үз л дээ, эрхэм Мериадок минь, хэдийгээр чи зэр зэвсэгтэй, биендээ багтахааргүй эр зоригтой ч гэсэн Гондорын нийслэлийн хэрмийн дэргэд биднийг хүлээж байгаа тийм аюумшигт дайнд чиний хэрэг гэж юу байхав дээ – гэж Теоден хэлэв

- Юу болохыг хэн мэдлээ, тэгвэл эзэн захирагч та намайг яах гэж зэвсэг баригч дагуулаараа томилсон юм бэ? Тулалдаанд дэргэдээ байлгах гэж томилоогүй гэж үү? Би бүх юмны ард үлдэж хоцроод байвал хожим хойч үеийнхэн энэ дайны тухай дуундаа намайг юу гэж оруулах вэ? – гэж Мерри зэрэв.

- Чамайг хамгаалахын тулд дагуулаараа томилсон юм. Миний дэргэд байвал чамд амар байсан. Харин аян дайнд бол чи надад зүгээр илүү дарамт болно. Миний шилтгээний

хаалганы дэргэд дайн болсон бол чамайг хойч үеийнхэн тэр дайны тухай дуундаа сайнаар дурсах байсан байж магадгүй. Харин Денэторын захирдаг Мундбург хүртэл зуу гаруй бээрийн зайтай. Энэ бол чамд хэлэх миний сүүлчийн үг.

Мерри мэхийн ёслоод дайчдын жагсаалын хажуугаар уруу царайлан алхав. Дайчид бүгд бэлэн болжээ. Бүсээ чанга бүслэн, олом жирмээ чангалж, морьдоо энхрийлэн илж, зарим нь харласан тэнгэр рүү түгшүүртэй харж зогсов. Хэн нэгэн мань хоббит руу хүрч ирээд:

- “Чин зоригийг баривал чиний өмнө чулуун хана ч нурна” гэж манайхан ярьдаг юм. Би энэ үгийг өөрийн биеэр туршсан юм – гэж шивнэн хэлэхэд дээш харвал өглөөний харц тулгарсан идэр дайчин байв.

- Чиний царайг харваас чи эзэн захирагчтай хамт явахыг хүсч байгаа юм аа даа?

- Тийм ээ, хүсч байна.

- Тэгвэл надтай хамт яв, би чамайг урдаа суулгаад, цуваараа хучна. Цаашлах тусам харанхуй болно. Чи их зоригтой юм байна – тиймээс хүссэнээрээ бол. Хэнтэй ч бүү үг соль, явцгаая!

- Маш их, маш их баярлалаа! - гэж Мерри түгдрэн байж хэлээд – Баярлалаа чамд, ноён... уучлаарай, нэрийг чинь мэдэхгүй.

- Мэдэхгүй гэв үү? – гэж идэр дайчин асуугаад: - За яахав, намайг Дернхельм гэж дуудаж болно.

Тийнхүү эзэн захирагч Теоден аян дайнд мордоход Дернхельм хэмээх дайчны урд, Шуурган хэмээх том саарал морин дээр нь бяцхан хоббит Мериадок сундалдан давхилаа. Дернхельм чийрэг биетэй, гавшгай шалмаг нь гайхамшигтай авч моринд хөнгөдөх жижиг биетэй тул Шуурган тэр хоёрт түүртсэнгүй.

Дайчдын цуваа харанхуй руу давхин оров. Эдорасаас арван хоёр бээрийн зайд, Цасан гол, Онтава гол хоёрын уулзварт, бутан төгөл дотор хоноглов. Дараа нь Фольд, Фенмаркаар дайрч, сийрэг царсан ойт толгодын хажуугаар давхилаа. Гондорын хил хүрч Онтава голын сав газарт тэд дайны тухай мэдээ сонслоо. Эр зориг, эрч чадал заан амьд гарч ирсэн ганц нэгээрээ дайчид Гондорын өмнө талаас тоо томшгүй олон орхуудын арми дайрч орсон, дайснууд Ристанийн талаар дүүрсэн тухай ярилаа.

- Урагшаа! Урагшаа! - хэмээн Эомер захирч: - Буцах ойройтсон, Онтавын намаг биднийг хоёр жигүүрээс хамгаална. Түргэлцгээе. Урагшаа!

Эзэн захирагч Теоден Ристанииг ардаа орхилоо, түүний дайчид төгсөлгүй мэт тахирласан замаар хурдалж, баруун талд Кэленхад, Мин-Риммон, Эрелас, Нардолын оргилууд сүүхийлцэн гарч ирэв. Гэвч тэдгээрийн оргил дээр дохионы гал харагдсангүй. Дүнсгэр хязгаарт аймшигтай нам гүм оргиж, урдаас нь харанхуй өтгөрөн, зүрхэнд найдварын гал бүдгэрч байлаа.

Бүлэг 4

Гондорыг дайлаар

Пинчийг Гэндальф сэрээв. Асаалттай дэнлүүнүүдээс дулаан гэрэл цацарч, цонхны цаана бүрэг харанхуй, аянга цахилгааны өмнөх шиг бүгчим байлаа.

- Хэдэн цаг болж байна? – гэж Пин эвшээнгээ асуув.

- Гурав дахь цаг, - гэж Гэндальф хариулаад – Босох цаг боллоо, чи чинь албаны хүн. Хотын захирагч чамайг дуудаж байна, даалгавар өгөх гэж байгаа.

- Бас өглөөний хоолоор дайлах уу?

- Үгүй ээ! Чиний өглөөний хоол энэ байна, үд болтол идэж ууна гэж бүү горьд. Цадтал чинь хооллохгүй, дасах хэрэгтэй.

Пин ганц зүсэм талх, дэндүү жаахан шар тос руу урамгүйхэн харав. Бас нэг аяга шингэн сүү байна.

- Чи ер нь яах гэж намайг энд авчирсан юм бэ? – гээд Пин санаа алдав.

- Яагаад гэдгийг чи сайн мэдэж байгаа, - хэмээн Гэндальф үгийг нь таслаад – Дахиад хэрэг тариулахгүйн тулд, хэрэв энд байх чамд таалагдахгүй байвал бусдыг бүү буруутга, өөрөө буруутэй.

Пин амаа хамхив.

Тэгээд Гэндальфыг даган Цамхгийн өргөөний хаалганы зүг урт хүйтэн хонгилоор алхлаа. Денэтор саарал мананд нуугдсан мэт хөдөлгөөнгүй сууж байв. “Яг л хөгшин аалз шиг, өчигдөр оройноос хойш одоо болтол хөдлөөгүй байх” – гэж Пин бодов. Гэндальфыг суу гэж дохисон ба Пин зогссоор байв. Эзэн түүн рүү харсан ч үгүй. Гэвч удалгүй түүнд хандсан үгийг нь сонсов:

- За сонин юу байна, ноён Перегрин, өчигдөр чи сайхан зугаалж, олныг үзэж харсан гэж найдаж байна. Нэг гэм нь өдгөө хоол унд ядмагхан байна, чи ийм байдалд дасаагүй байх гэж л айж байна.

Хэн ч, юу ч хэлсэн, юу ч хийсэн эзэн захирагч тэр дор нь мэддэг, түүний хувьд бусдын санаа бодол нууц биш юм байна гэж Пин бодов. Тиймээс дуугарсангүй.

- Чамайг ямар албанд томилох вэ?

- Үүнийг та надад хэлэх байх гэж би бодсон юм, эзэн минь.

- Юу хийж чадахыг чинь мэдсэн хойноо хэлье, миний дэргэд байж байвал одоохон мэднэ –

гэж Денэтор амлаад – Миний өргөөний зарлага тэргүүн шугамын хороонд алба хаая гэж гуйсан, чи одоогоор түүнийг орлож бай. Надад үйлчилнэ, миний зарлигийг дамжуулна, дайн байлдааны болоод зөвлөлийн чөлөөгөөр надад юм ярьж өгнө. Чи чадах уу хө?

- Чадна аа, - гээд Пин – гэхдээ манай нөхцөлд л чадна. Манай дуунууд эндхийн өндөр хүнхэр шилтгээнд тохирохгүй, өнөөгийн цаг үед ч тохирохгүй эзэнтэн минь. Манайханд хамгийн аюултай юм юу вэ гэвэл аадар бороо, цасан шуурга хоёр. Тэгээд ч бид ямар нэг инээдэмтэй юмны тухай л дуулдаг, манай дуу бол найрын дуу.

- Танай тэр дуунууд манай энд, манай энэ үед тохирохгүй гэж чи бодож байна уу? Аймшигт сүүдэр нөмөрсөн бидэнд алсын гэрэлт орны хөгжилтэй дууг сонсох аятайхан бус уу? Бид танай ч, бусад орны ч хил хязгаарыг хамгаалахдаа хэн ч бидэнд талархал илэрхийлэхгүй гэж бодоогүй юм шүү.

Пин тун чиг урам хугарав. Ингэх л дугаж гэнэ. Минас-Тиритийн эзэн захирагчид хоббитуудын хошин дуунуудыг аялах гэж үү? Энэ талаар тэр хэнээс ч илүү мэдлэгтэй билээ.

Гэвч энэ удаа дуулах хэрэг гарсангүй. Хошин дуу дуул гэж түүнд тушаасангүй. Денэтор Гэндальфаас Мустангрим орны тухай, тэндхийн төр улсын хэрэг, эзэн захирагчийн үеэл дүү Эомерын тухай сонирхов. Пин бүр алмайртлаа гайхав. Энэ улсын эзэн хаан харь орнуудын тухай яаж ийм их юм мэддэг байна аа? Өөрөө өөрийнхөө улсын хилээс гадагш гараагүй маш олон жил болсон доо.

Эцэст нь Денэтор Пин руу гар дохиж – Яв яв, одоохондоо хэрэггүй гэсэн дохио өгөв.

- Зэвсгийн сан руу оч, цамхгийн харуул ямар байдлаар хувцаслах ёстой вэ, тэгэж хувцаслаж, зэвсэглэ. Тэнд бүх юм чамд бэлэн байгаа, өчигдөр би тушаал өгсөн.

Үнэхээр бүх юм бэлэн хүлээж байлаа. Пин ер бусын хар - мөнгөн өмсгөлтэй болов. Харлуулсан гангаар хийсэн бололтой хөө хуяг, хоёр талдаа хар өдтэй, урдаа мөнгөн одтой шовгор оройтой дуулга, хөө хуягны гадуур мөнгөн утсаар модны дүрс шагласан хар цув өмслөө. Өмсч байсан хувцаснуудаа эвхэж боогоод хадгалав. Лориэний саарал цувыг үлдээсэн боловч албан дээрээ өмсөхийг зөвшөөрөхгүй гэлээ. Ингээд тэр гондорчуудын хэлээр жинхэнэ Эрнил-и-Ферианнат буюу одой ван болж хувирсан нь өөрт нь таалагдахгүй байв. Дээрээс нь харанхуй улам уйтгарлуулна.

Харанхуй өдөр болов. Өглөөнөөс орой болтол таг харанхуй, Гондорын дээгүүрх харанхуй утаа хүндэрч, амьсгалахад бэрх болов. Тэнгэрт асар том хүнд хар үүл баруун тийш хөврөн гэрэл залгиж, газар дээр бүгчим харанхуй. Андуины хөндий тэр чигээрээ аймшигт шуурганы өмнөх шиг байлаа.

Арван нэгэн цагт түүнийг түр гадуур гарахыг зөвшөөрсөн тул Пин цамхгаас гарч, идэж уух юм хайхаар явлаа. Хоол унд өгөх нь ойлгомжтой, далимд нь жаахан зугаалаад авья хэмээн шийджээ. Ордны алба түүнд яршигтай санагдаж байжээ. Хоолны танхимд тэр Бергондыг харав. Тэр пеленнорын хил дээрх харуулын цамхгаас дөнгөж орж иржээ. Пин түүнийг хэрмэн дээгүүр жаахан алхая гэж гуйлаа. Тэр хоёр зүүн зүг рүү харсан шагайвчийн дэргэд суув. Энд

Тэр хоёр анх удаа уулзан хооллож, ярилцаж байсан билээ.

Нар жаргах дөхөж байсан боловч харанхуй тэртээ баруун тийш одож, Тэнгисийн цаана гарсан хойно л нар түүний араас үдэлтийн туяагаа арай ядан илгээж байх шиг.

Пин энд бүр олон жилийн өмнө, ямар нэг мартагдсан цаг үед юуг ч үл ажирдаг хэнэггүй тэнүүлч хоббит байхдаа сууж байсан юм шиг санагдав. Одоо тэр жижигхэн дайчин, цагаан чулуун хотыг аймшигт аюулаас хамгаалагч болсон, цамхгийн хамгаалагчийн ихэмсэг бараан өмсгөлтэй сууж байна.

Өөр цаг үед, өөр газар байсан бол Пин ийм өмсгөлөөрөө бахархах байсан биз, гэвч одоо түүний ажил тоглоом биш, түүний амь насыг ширүүн зант эзэн захирагч мэднэ, толгой дээгүүр үхэл нөмрөөстэй байгааг тэр ойлгож байлаа. Хөө хуяг бие барьж, дуулга хоёр шанаанаас нь хавчиж байх шиг санагдана. Тэр цуваа тайлж, сандал дээр тавив. Ядарсан нүдээрээ тэртээ дор бараантаж байгаа тарианы талбайг хараад эвшээж, гашуунаар санаа алдав.

- Яасан бэ, ажилдаа ядрал уу? – гэж Берегонд асуулаа.

- Ядартлаа ажилласан бол ч яахав, хий дэмий цаг нөхцөөсөндөө л сөхөрч унах гээд байна. Эзэн маань Гэндалф, Имраилийн ван болон бусад том зочдыг хүлээн авч, ярилцаж байхад үүдэнд нь хэдэн цаг эргэлдлээ. Би сайхан хоол идэж байгаа хүмүүсийг хараад өлөн ходоодоо хоржигнуулан тэдэнд үйлчилж сураагүйг чи мэдэхгүй л дээ, Берегонд. Хоббитууд ийм юм мэддэггүй. Гэлээ ч гэсэн нэр хүндтэй ажил гэж чи хэлэх байх! Ийм нэр хүндээр юугаа хийх юм бэ? Тэгж ярих юм бол энэ мөлхөө харанхуй дор идэж уух хэрэг ч юу байна! Чамд харанхуй санагдахгүй байна уу? Харахгүй юу, агаар гэхэд агаар биш, нэг хачин хүрэн хар зуурмаг! Салхи танай энд өмнөдөөс байнга ийм хар манан тууж ирдэг үү?

- Үгүй дээ, - гэж Берегонд хэлээд – Цаг агаар энд ямар ч хамаагүй. Энэ бол дайсны хийж байгаа ажил. Галт уулын гүнээс л энэ муухай хар утааг гаргаж ирсэн байх. Энэ утаа сэтгэл санаагаар унагаж, оюун ухааныг будантуулж байна, дайсанд яг энэ л хэрэгтэй шүү дээ. Фарамир л хурдан эргэж ирээсэй! Харин тэр Мөрний цаанаас, тэндхийн сохор харанхуйгаас гарч ирж чадах нь уу, үгүй юу?

- Харин ээ, Гэндалф ч гэсэн түүнд санаа зовж байгаа. Фарамир хотод байхгүй байгааг сонсоод тэр их урамгүй байсан. Ингэхэд Гэндалф өөрөө хааччихав аа? Зөвлөл дээрээс бүр үдийн хоолны өмнө гарсан, их баргар царайтай байна лээ. Сайн юм болохгүй нь гэж мэдсэн байх аа.

Тэр хоёр гэнэт үгээ таслан хөшөө мэт зогсов. Пиний бие агзасхийж, хоёр алгаараа чихээ таглахад Фарамирын тухай яриад шагайвчийн дэргэд зогсч байсан Берегонд тэндээ нам зогсоод айдас дүүрэн нүдээрээ харанхуй руу ширтэж байв. Пин энэ хачин зэвүүн орилооныг Хоббитанид, их Намагт байхдаа сонсч байсан билээ. Гэвч энд түүнээс ч илүү чанга, хорсол хилэнтэй сонсогдож, зүрх амаар гартал айлгаж байв. Эцэст нь Берегонд хүчлэн байж хэлэв:

- Хүрээд ирцгээчихэж! Зоригоо хөвчлөөд хар! Энэ байна, тэр аймшгийн новшнууд.

Пин сандал дээр дургүйхэн гарч зогсоод, шагайвчаар харав. Манант хар сүүдэрт хучигдсан Пеленнор, цаана нь Их мөрөн дөнгөж үзэгдэх төдий. Газар дээгүүр, хэрэмний дундад өндөрт шөнийн арвагар сүүдэр мэт шувуутай төстэй ч юм шиг, тэмээлзгэнэтэй ч төстэй юм шиг, ямар ч том бүргэдээс том таван хар юм эргэлдэж, тэдний зүгээс үхэл үнэртэх мэт санагдав. Тэд хэрэм дээрээс харвасан сум хүрэхээр ойртож ирснээ мөрөн рүү эргэж алга болов.

- Хар морьтнууд! - хэмээн Пин дуу алдаад – Хар морьтнууд тэнгэрт гарчихаж! Хараач, Берегонд! – гэж тэр гэнэт хашгираад – Тэд нэг юм хайж байгаа нь илт байна! Яаж эргэлдэж, дараа нь доош шумбаж байгааг, аа хайж байгаа юм нь тэр байна! Газраар нэг юм хөдөлж байгааг харж байна уу? Жижигхэн бараан юмнууд... тийм байна, морьтой хүмүүс – дөрөв юм уу, таван морьтон. Хүүе ээ, дахиад л! Гэндальф! Гэндальф, биднийг авраарай!

Дахиад аймшигтай, зүрх чичрэм зэвүүн орилоон сонсогдоход Пин хананаас үсрэн зайлж, хөөгдсөн араатан шиг чичрэн амьсгаадав. Гэвч дараа нь тэртээ доор эвэр бүрээний тасалданги дуу дөнгөж сонсогдоод үрэлжилсэн чанга орилоонд дарагдав.

- Фарамир! Энэ бол Фарамир! Энэ түүний дохио мөн байна! - гэж Берегонд хашгирав – Ийм л эрэлхэг баатар даа! Харин энэ нисдэг шуламнууд орилохоос өөр аймшигтай юм хийж чадна шүү дээ, тэр яаж хаалга хүртэл давхина даа! Хараач, давхисаар байна, бүр ойртоод ирлээ! Ээ, морьд нь айчихлаа!, Эзнээ булгиад шидчихлээ ... босоод гүйцгээж байна... гүйгээд бай! Нэг нь мориноосоо унаагүй байна, нөхөд рүүгээ эргэж давхилаа. Энэ ч Фарамир даа, - түүнд хүмүүс ч, адуу ч захирагддаг юм. Аа муу хараал идмэрүүд, тэр дайрч байгааг нь хараач! Туслаач ээ, та минь, туслаач! Тэнд юу болоод байна аа? Фарамир! – гэж хашгираад Берегонд ганцхан хайрайгаад харанхуйн дунд алга болов.

Пин өөрөөсөө ичив. Берегонд удирдагчаа аврахаар эргэж ч харалгүй аюул руу яарч байхад чи юундаа айдастаа хүлэгдээд энд юу ч хийлгүй хэвтэж байдаг билээ? – хэмээн өөрийгөө зэмлээд дахин шагайвчаар харав. Хойт зүгт нэгэн мөнгөлөг цагаан од гялсхийснээ бараантах тал руу харвалаа. Үгүй ээ, харвасан биш юм байна, сумнаас ч хурдан давхиж байгаа юм байна, улам хурцаар туяаран гэрэлтэж, хаалга руу гүйж байгаа дөрвөн дайчинд хүрлээ. Түүний тод цагаан туяа хар сүүдрийг хөөж байгаа юм шиг Пинд санагдав. Тэр гэрэл улам ойртож ирэхэд хэрмийн ханануудад хүчирхэг уриа цууриалав.

- Гэндальф! – гэж Пин хашгираад: - Гэндальф! Ямар ч найдвар байхгүй болсон цагт тэр яг дэргэд хүрээд ирдэг! Урагшаа! Цагаан морьтон минь! Гэндальф, Гэндальф! – хэмээн уралдаан үзэж суугаа хурдан морины хорхойтон хэнд ч юм, яах гээд ч юм хашгирдаг шиг байдаг хоолойгоороо бархирч байв.

Эргэлдэж байсан хар сүүдрүүд цагаан морьтонг хараад нэг нь түүн рүү шумбан дайртал цагаан морьт гараа өргөх шиг болоод цагаан аянга дүрэлзэхэд хар аймшиг амь тавин бархирсаар зугтахад бусад дөрөв нь тэрнийхээ араас зайлан өмнө зүг рүү алга болов. Пеленнорын тал түрүүнийхээсээ арай гэгээтэй боллоо.

Цагаан морьт, бараан морьт хоёр уулзаж, явган ирж яваа дөрвийгөө хүлээж байгааг Пин харж байв. Хотоос дайчид угтан очиж, удалгүй тэд хэрэм дээрээс харагдахгүй болсныг бодоход дотогшоо оржээ. Тэд одоохон дээшээ гарч ирээд, эзэн захирагчид бараалхана гэж бодоод Пин

тэднийг өргөөний өмнө угтахаар гүйв. Тэнд хэрмэн дээрээс хөөцөлдөөнийг харж, санамсаргүй авралын гэрч болсон олон хүн аль хэдийн цугларчээ.

Удаан хүлээсэнгүй, хажуугийн гудамжнаас олон хүмүүсийн баяр хүргэсэн дуу шуугилдаж, Фарамир, Митрандир гэсэн нэр олонтоо сонсдож байв. Пин олны дотор наашилж байгаа хоёр морьтны бамбарыг харлаа. Нэг нь цагаан өмсгөлтэй байсан боловч цагаан гэрэл дотогшлон бүдгэрсэн, нөгөө нь бараан өмсгөлтэй байлаа. Тэд яаран гарч ирээд, Аянга болон нөгөө морийг морь маллагчдад өгч, хаалганы харуул дээр ирэв. Гэндальф саарал нөмрөгөө намируулан, сүрлэг харцаа өргөсөөр ширүүхэн алхалж, ногоон өмсгөлтэй нөгөө дайчин нь хэтэртлээ ядарсан юм уу, шархадсан шинжтэй найгасхийн удаанаар алхана. Пин тэднийг нуман хаалганы дорхи дэнлүүнд дөхөж ирэхэд нь хүмүүсийн суган доогуур урагш зүтгэн гарч ирсэн боловч Фарамирын цонхийсон царайг хараад амьсгаа түгжин зогсов. Тэр үхлийн аймшиг, айдас, зовлонг давж гараад өөрөөрөө үлдсэн нь илт байлаа. Тэрбээр харуулын дэргэд зогсоод хэдэн үг сольж байгаа нь тайван агаад ихэмсэг харагдана. Пин түүнийг харж байхдаа ах Боромиртойгоо ямар их адилхан юм бэ гэж гайхав. Боромир бүр Уудам хөндийд байхад л ихэмсэг сүрлэг дүртэй мөртөө эелдэг зөөлөн зангаараа Пинд шууд л таалагдсан билээ. Гэвч Фарамир түүний анхаарлыг огт өөрөөр татаж байв. Пинд урьд нь ийм мэдрэмж төрж байсангүй. Тэр Арагорныг санагдуулам агуу сайхан сэтгэлтэй, магадгүй түүнээс арай бага ч байж мэдэх юм, тэгэхдээ ойрхон бөгөөд ойлгомжтой сайхан сэтгэлтэй жинхэнэ ихэс дээдсийн төрхтэй байв. Тэр хоёр өөр өөр үеийн баатар вангууд боловч эртний мэргэн ухаан, эртний уй гашууг уламжилж авсан байна. Бергонд түүний тухай тийм их халуун сэтгэлээр ярьж байсан нь дэмий хэрэг биш ажээ. Тийм удирдагчийн араас гал руу ч яваад орно, Пин бол бүр хар далавчны доогуур яваад ороход ч бэлэн байв.

- Фарамир! - Фарамир! – гэж тэр чанга хашгирахад Фарамир олны дуу хоолой дотроос нэг л содон дуу хоолой сонсоод эргэж харснаа гайхсандаа нам зогсов.

- Чи хаанаас гараад ирэв ээ? Цамхгийн харуулын өмсгөлтэй жижиг биет хаанаас?..

Энэ асуултад тэр хоёр руу дөхөж ирсэн Гэндальф хариулав:

- Өөрийнхөө орноос, жижиг биетүүдийн хязгаараас ирсэн юм. Ингэхэд би түүнийг авчирсан. Явья, явья, ажил их байна, ярих юм ч их байна, чи дөнгөж амьтай байна. Тэр бидэнтэй хамт орно. Тэр ч гэсэн бидэнтэй хамт орох ёстой. Би бүр мартчихаж, энэ ч бас их эр шиг байна, аль эрт эзнийхээ дэргэд зогсч байх ёстой биш үү? Явья, Пин, битгий хоцроорой!

Тэр гурав ордны мухарт байдаг амрах өрөөнд оров. Тэнд улайссан нүүрстэй зуух тойруулан суудал дээр суухад дарс авчирч өглөө. Пин Денэторын ард үл үзэгдэгч мэт зогсоод ядарснаа мартан тэдний үг бүрийг хомхойлон сонсч байв.

Фарамир цагаан талх хазаж, дарс балгаад аавынхаа зүүн гар талд суув. Баруун гар талд нэлээд зайтай Гэндальф суугаад эхэндээ бараг зүүрмэглэж байв. Учир нь Фарамир эхлээд арав хоногийн өмнө авсан даалгавраа яаж биеүүлсэн тухайгаа яриу. Итилид болж байгаа үйл явдлууд, Дайсан болон түүний хамсаатнуудын цэрэг хаана хаана орж ирснийг, замын ойролцоо болсон тулалдааны тухай, тэр тулалдаанаар байлдааны аварга том араатантай хородримын том бүлгийг бутниргэсэн тухай яриу. Товчоор хэлэхэд хил хязгаараа эргээд ирсэн

жанжин эзэн хаандаа өчигдөр тулгамдсан чухал асуудал байсан, өнөөдөр өчүүхэн жижиг болсон асуудлуудаар мэдээлэл хийв.

Дараа нь Фарамир гэнэт Пин рүү хараад:

- Одоо хачирхалтай сонин юм ярья, умардын домгуудаас өмнөд рүү зөвхөн энэ жижиг биет ирээгүй юм байна – гэлээ.

Тэгэхэд Гэндальф нуруугаа эгцлээд, буйдан сандлын түшлэгийг базан өндөсхийсэн боловч үг хэлсэнгүй, харин хариугүй хашгирах шахсан Пинийг харцаараа нам болгов. Денэтор тэр хоёр руу зэрвэс харснаа толгойгоо удаанаар дохисон нь, тийм ээ би бүгдийг мэдэж байна гэсэн дохио бололтой. Фарамир голдуу Гэндальфад хандаж яаралгүй ярихдаа байн байн Пин рүү харцаа шилжүүлж байсан нь - танай нөгөө хоёр чинь – гэж сануулсан хэрэг байв. Бусад нь дуугүй сонслоо.

Фарамир, Фродо дагуултайгаа хэрхэн тааралдсан, тэд Хеннет-Аннунед хоносон тухай ярихад Гэндальфын гар чичирч, сандлын түшлэг базаж байгааг Пин анзаарав. Түүний гар гурил шиг цагаан арьстай, тун ч их хөгшин ажээ. Тэр гар руу харж байхдаа Гэндальф сэтгэл түгшсэн төдийгүй айж байгааг ойлгов. Маш бүгчим байлаа. Фарамир Кирит-Унгол руу явахаар шийдсэн хоёр аянчинг үдэж гаргасан тухайгаа яриад дуугүй болж, толгой сэгсрэн санаа алдав. Гэндальф босон харайлаа.

- Кирит-Унгол руу юу? Моргулийн хөндийгөөр үү? Хэзээ тэр вэ? Хэзээ чи тэднээс салсан бэ? Тэр үхлийн хөндийгөөр туулахад хичнээн хугацаа хэрэгтэй вэ?

- Би тэднээс гурав дахь өдрийн өглөө салсан. Тэд Моргулдуинаар арван таван бээр явна, хэрэв өмнө зүг рүү шууд явбал шүү дээ. Тэндээс таван бээр гаруй яваад хараалт цамхаг хүрнэ. Өнөөдрөөс эрт тэд хүрч чадахгүй, магадгүй одоо ч замд явж байгаа болов уу. Би чиний авралыг ойлгосон. Үгүй ээ, тэднээс болоод хар сүүдэр нөмөрч байгаа юм биш. Харанхуй өчигдөр орой мөлхөж ирээд шөнийн дотор Италийг бүрэн нөмөрсөн. Дайсан бүр аль эрт бүгдийг тооцоолсон байна, тэр довтолгоогоо яг өдөрт нь, яг цагт нь хийж байна, манай тэр аянчид энд ямар ч хамаагүй.

Гэндальф хойш, ургаш алхав:

- Уржигдар өглөө гэдэг чинь бараг гурав хоногийн өмнө гэсэн үг! Та нар хаана салсан бэ? Эндээс хол уу?

- Шувууны нисэлтээр хорин таван бээр - гээд - гэхдээ би үүнээс хурдан эргэж ирж амжаагүй. Бид үдэш Каир-Андрост харуул хийж байсан, энэ бол их урт голын арал, тэнд манай умард застав байгаа, морьд наад эрэг дээр байсан. Дөрвөн морь. Харанхуй нөмрөөд ирэхээр би алгуурлаж болохгүй гэж ойлгоод гурван дайчнаа аваад, бусдыг нь Осгилиатын гарам дээр байгаа отрядад хүч нэмэгдүүлэхээр илгээсэн. Би зөв шийдвэр гаргасан байх гэж найдаж байна – гээд тэр эцэг рүүгээ харав.

- Зөв гэж үү? – гэж Денэтор асуухад нүд нь гялалзав. – Яагаад чи энэ тухай надаас асууж

байгаа юм бэ? Чиний захиргаанд хүмүүс байсан. Чи надтай зөвлөөд дасчихсан гэж үү? Чи надад хүндэтгэлтэй ханддаг боловч ямагт өөрийнхөөрөө шийддэг, надтай зөвлөлгүй шийддэг. Одоо ч гэсэн чи Митрандираас нүд салгахгүй байна: - Би санамсаргүй илүү үг хэлчихээгүй биз? – гэж асуугаад байгаа юм биз дээ. Тэр чамайг эрт өөртөө татсан шиг байна.

Хүү минь, аав чинь хөгширсөн ч гэсэн хараахан зөнөчихөөгүй байна. Би урьдын адил бүгдийг харж, бүгдийг мэддэг хэвээрээ байна. Чиний хагас дутуу ярьсан, хэлэлгүй өнгөрснийг чинь амархан мэдэж чадна. Надаас юм нууж чадна гэж үү. Боромир минь амьд байсан ч болоосой!

- Чи миний хувьд сэтгэл хангалуун биш байх шиг байна, аав минь - гэж Фарамир тайван хариулаад, - Чамайг яаж шийдэх байсныг мэдэхгүйгээр ийм чухал шийдвэр гаргах болсон минь харамсалтай байна

- Чи өөрөөр шийдэх байсан гэж үү? - гэж Денэтор дооглонгуй асуугаад – Ингэж л шийдэх байсан, би чамайг мэдэж байна. Чи эртний хаадыг өөртөө үлгэр жишээ болгож аваад тэдэнтэй адил агуу бөгөөд ихэмсэг, сайхан сэтгэлтэй, өгөөмөр, өршөөлт эзэн байх гэж хичээдэг. Өндөр язгуурт удмын эзэн ертөнцийг захирч байгаа цагтаа тийм л байх ёстой. Гэвч ийм цөвүүн цагт өгөөмөр загнавал амь насаараа төлөх ч хэрэг гарч мэднэ.

- Болтугай - Фарамир хэлэхэд:

- Тэгэх болно! – гэж Денэтор хашгираад - Чи зөвхөн өөрийнхөө амиар төлөхгүй, миний хайрт Фарамир минь, чиний эцэг, чиний ард түмэн үхнэ. Боромир байхгүй болохоор чи л энэ ард түмнийг хариуцна.

- Чи миний оронд тэр байхыг хүсэх байсан уу, эцэг минь?

- Мэдээж, хүсэх байсан, Боромир надад үнэнч байсан, ямар нэг явуулын шидтэнд биш. Тэр эцгээ мартаж, хувь заяаны бэлгийг шидэхгүй байсан! Тэр надад тэр агуу бэлгийг авчирч өгөх байсан.

- Гуйя эцэг минь – хэмээн эцэстээ тэсвэр алдсан Фарамир хэлээд – танаас гуйж байна, яагаад өнөөдөр Итилид түүний оронд би очсоныг сана. Цагтаа, таны шийдвэрээр Боромир замд гарсан.

- Миний тэртэй тэргүй шорвог аяганд давс бүү хий - гэж Денэтор хэлээд – олон нойргүй шөнө би энэ аяганаас хор ууж байна, тундас нь бүр ч шорвог болов уу гэж бодож байна. Тэр тундас нь энэ боллоо. Чи юу хийх чинь энэ вэ! Хэрэв тэр бэлэг надад ирсэн бол доо!

- Тайвшир! - гэж Гэндальф хэлээд – Тэр чамд олдохгүй байсан, Боромир тэрнийг чамд өгөхгүй байсан. Тэр баатрын ёсоор амь үрэгдсэн, амарлингуйн орноо залрах болтугай! Гэвч чи өөрийгөө хуурч байна. Тэр чиний ярьж байгаа зүйлийг авсан бол өөртөө үхэл авчрах байсан. Хэрэв Боромир түүнийг аваад ирсэн бол чи хүүгээ танихгүй байсан.

Денэтор түүн рүү хатуу бөгөөд хүйтнээр харлаа.

- Тэрнийг захирахад тийм амар биш юм биз дээ? – гэж тэр аяархан хэлээд – Би Боромирын эцэг, тэр надад түүнийг авчирч өгөх байсан гэж би баталж байна. Чи, Митрандир, мэргэн байж болох л юм, гэвч өөрийгөө хэтэрхий мэргэн болгоод байгаа юм биш биз? Ид шидийн үзүүлбэр, хуумгай шийдвэр хоёроос өөр мэргэн ухаан байдаг юм. Надад тэр ухаан чиний бодож байгаагаас их бий.

- Чиний мэргэн юундаа байгаа юм бэ? - гэж Гэндальф асуув.

- Наанадаж юу хийж болохгүй вэ гэдгийг би мэднэ. Тэрнийг ашиглаж болохгүй, энэ бол аюултай. Гэвч өнөөгийн энэ хүнд үед тэрнийг толгойгүй одойд өгөөд Дайсны гарт оруулахаар явуулна гэдэг солиорол. Чи ийм юм хийсэн, чиний араас миний бага хүү хийлээ.

- Эзэн захирагч Денэтор яах байсан бэ?

- Өөрийнхөөрөө хийх байсан. Гэхдээ ямар ч тохиолдолд тэрнийг аз туршин явуулахгүй байсан, хэрэв Дайсан бүхнийг дийлэгч хүчээ эргүүлж авбал биднийг сүйрлийн аюулд унагана шүү дээ. Үгүй ээ, тэрнийг харанхуй, хэн ч хүрэхгүй хамгийн гүн ёроолд булах байсан юм. Амин чухал хэрэгцээ гараагүй цагт тэрэнд гар хүрч болохгүй. Дайсан тэрнийг гартаа оруулж биднийг бүгдийг нь устгуулахгүйн тулд тэрнийг үүрд булах байсан юм. Үхдлүүдээ л захирч байдаг юм байгаа биз.

- Эзэнтэн чи урьдын адил зөвхөн Гондорыгоо л бодоод байна, өөр хязгаар, өөр газар орон, өөр ард түмнүүд байдаг юм, чиний үхэл ч цаг хугацааг зогсоохгүй. Надад ... тэр бүү хэл тэрний дуулгавартай боолууд ч харамсалтай байна – гэж Гэндальф хэлэхэд:

- Бусад ард түмэнд Гондор уначихвал хэн туслах юм бэ? - хэмээн Денэтор зөрүүдэлж – Тэр одоо миний хэрмийн доорх газар доор хэвтэж байсан бол бид өнөөдөр харанхуйд айж мэгдэж, урьд өмнө үзэгдээгүй аймшгийг хүлээж байхгүй байлаа. Бид гурав ч одоо зөвлөгөөн хийхээс биш, хэрэлдэж суухгүй байлаа. Надад тийм хүч байхгүй гэж чи бодож байна уу? Намайг муу л мэдэж байна даа чи.

- Гэлээ ч гэсэн чиний хүч хүрэхгүй гэж бодож байна – гэж Гэндальф хэлээд - Хэрэв би тэгж бодоогүйсэн бол би тэрнийг зүгээр л чамд хадгалуулахаар нааш нь илгээх байсан, ингээд л гүйцээ. Чиний саяны хэлснийг сонсоод чамд хэлэхэд, Боромир чамаас илүү найдвартай санагдаж байсан юм шүү. Тогтож айлд, бүү хилэгнэ! Би өөртөө ч найдаагүй, тиймээс тэрнийг надад бэлэглэхэд нь би хүлээж авахаас татгалзсан. Чи сэтгэлийн хат ихтэй, Денэтор, одоогоор чи бүх юманд биш ч гэсэн өөрийгөө захирах тэнхээтэй байна, гэхдээ л тэр чамаас хүчтэй. Чи түүнийг Миндоллуины доогуур уулын гүнд хаялаа гэхэд тэр тэндээс ч гэсэн чиний оюун ухааныг самууруулж чадна, учир нь тэр харанхуйд улам хүчтэй болдог юм, харанхуйгаас ч гүн энэ харанхуйг ойртох тусам тэр агуу их хүчтэй болно.

Денэторын гялалзсан нүд дахин Гэндальф руу тэмүүлж, тэр хоёрын харц ган илд мэт мөргөлдөхөд гал бутарч байх шиг Пинд санагдав. Тэр айж байлаа, аянга ниргэвэл яана. Гэвч Денэтор гэнэт буйдан сандал дээрээ лагхийтэл сууж, гэдрэг налахад харц нь сулран зөөлрөв. Тэр мөрөө хавчаад:

- Хэрэв би! Хэрэв чи! – гэж тэр хэлээд – Хоосон яриа “хэрэв”-ээр эхэлдэг юм. Тэр харанхуйд алга болсон, тэр яасан, бидэнд юу тохиолдох вэ гэдгийг аяндаа үзнэ, тун удахгүй мэднэ... харин одоохондоо Дайсантай тулалдана, хэн яаж чадахаараа итгэл найдвараа дуустал тулалдана. Дараа нь чөлөөтэй үхэх эр зориг хүрэлцэх болтугай – гээд тэр Фарамирт хандаж: - Осгилиатад хэр их хүч бий вэ?

- Бага, - гэж Фарамир хариулаад: - Би өөрийнхөө Италийн дайчдыг тэдэнд туслуулахаар илгээснийг чи мэдэж байгаа.

- Дахиад хүч илгээх хэрэгтэй, эхний цохилт тэнд бууна. Тэнд бас найдвартай жанжин хэрэгтэй байна – гэж Денэтор хэлэв.

- Ганц тэнд биш, хаа сайгүй хэрэгтэй байна - гээд Фарамир санаа алдаж: - Ахынхаа тухай бодоход тун ч хэцүү байна, би гэсэн түүнд хайртай байсан!

Тэр босоод: - Намайг явахыг зөвшөөрнө үүү, аав аа? – гэж хэлэхдээ унах шахаж, аавынхаа сандлын түшлэгийг тулав.

- Чи их ядарсныг би харж байна, Чи их холоос давхиж ирсэн, дээгүүр чинь аймшигт сүг сүүдрүүд эргэлдэж байсан тухай надад мэдээлсэн - гэж Денэтор өгүүлэв.

- Тэр тухай ярих хэрэггүй! - гэж Фарамир хэлэв.

- Тэгвэл ярихаа больё. Явж амар, цагийн байдал хичнээн л бол амрах хугацаа олгоно, тэр хэмжээгээр амар. Маргааш өнөөдрөөс бэрх болно.

Тэр гурав эзэн захирагчийн өргөөнөөс гарав. Амрах цаг тун бага үлдсэн байлаа. Гэндальф, Пин хоёр жижигхэн дэнлүү барьсаар харанхуй дундуур байр руугаа явлаа. Хэн хэн нь замдаа нэг ч үг дуугарсангүй, хаалгаа онгойлгосны дараа л Пин Гэндальфын гарт зөөлөн хүрч:

- Хэлээд өгөөч надад, ядаж өчүүхэн ч гэсэн найдвар бий юу? Би Фродогийн тухай, бидний тухай ч гэсэн, гэхдээ эхлээд тэрний тухай асууж байна.

Гэндальф Пиний толгой дээр гараа тавилаа.

- Онцгой найдвар хэзээ ч байгаагүй, - гэж тэр хариулаад – Зөвхөн ухаангүй найдвар л байсан, энэ талаар Денэтор зөв хэллээ. Би Кирит-Унгол гэсэн нэр сонсоод ... – гэснээ үгээ тасалж, цонх руу очоод, харанхуйг нэвтлэн дорно газрыг харах гэсэн юм шиг харанхуй руу харж: - Кирит-Унгол! – хэмээн бувгнав. – Тэд яах гэж тийшээ явсныг мэдэх юмсан? – гээд эргэж: - Энэ үгийг сонсоод амьсгаа боогдох шиг болсон. Харин бодоод үзэхэд Фарамирын мэдээ тийм ч найдваргүй биш юм байна. Эргэлзээ алга. Дайсан дайныг эхлэхэд Фродо тэрэнд хараахан баригдаагүй. Тэгэхлээр тэр одоо өдөр шөнөгүй Хүрэн нүдээрээ Мордорын гадуурх газар нутгийг тэмтэрч байгаа. Гэхдээ тэр их яарч байгааг, хачирхалтай нь бүр айж байгааг нь би алсаас мэдэрч байна. Нэг л юм болсон байна, нэг л юм тэрнийг сандаргаад байна...

Гэндальф бодол болов.

- Магадгүй, найз минь, чиний тэнэглэл хэрэг болсон юм биш биз, найз минь. Байз байз, бид Саруманыг ялж, түшиц газрыг эзэлснийг тэр тав хоногийн өмнө мэдсэн. Тэгээд юу гэж? Тэрнээс ямар ч ашиг гарахгүй, тэгээд ч Дайсны нүднээс далдуур Чулууг харах боломжгүй. Аа! Арай Арагорн биш биз? Түүний мандах цаг нь ирж байгаа. Түүний хүч чадал Пин минь, хэмжээлшгүй, тэр алмаазнаас ч хатуу, хатан зоригтой, эрс шийдэмгий, юунд ч барьц алдаж сандардаггүй. Тиймээ, тэр л юм шиг байна. Тэр Чулуунд хүрч, дайсны өмнө ил гараад нэрээ хэлсэн байна. Тэрнийг айлгахын тулд ... нэрээ хэлжээ дээ. Тэгсэн л байна даа. Гэвч бид Ристанийн морьт дайчид давхиж ирэхээс өмнө тэгсэн үү, үгүй юу гэдгийг мэдэж чадахгүй. Харин битгий л хожимдоосой билээ. Биднийг ч аймшигтай өдрүүд хүлээж байна даа. Унтаж үзье!

- Харин... - гээд Пин түгдрэв.

- Юун “харин?” гэж Гэндалф ширүүхэн асуугаад - “Харин?” гэдэг асуулт юу юм бэ – тэгээд л гүйцээ.

- Хорлум энд ямар хамаатай юм бэ? - гэж Пин асуугаад – Яагаад тэр тэдэнд газарчилж байгаа юм бэ? Тэднийг дагуулж явсан газар Фарамирт таалагдахгүй нь мэдээж шүү дээ. Учир нь юундаа байна?

- Юуг мэдэхгүй вэ, тэрнийг мэдэхгүй – гэж Гэндалф хариулаад – Фродо, Хорлум хоёр заавал уулзана гэдгийг зүрх минь надад хэлээд байсан юм. Сайны дохио юу, муугийн ёр уу – бүү мэд. Кирит-Унголын талаар дахиад нэг ч үг бүү хэл. Урвалтаас би айдаг, урвалт аа гэж. Тэр өчүүхэн өөдгүй амьтан бариад өгчихөж магадгүй. Гэвч юу л болвол болог. Магадгүй, урвагч өөрийгөө хуураад өөрийн эрхгүй сайн үйл үйлдэж ч болох юм. Заримдаа тийм юм болдог л юм. Сайхан нойрсоорой!

Харанхуй өглөө болж, Фарамирыг ирэхэд итгэл найдвар нь сэргэсэн гондорчууд дахин уруу царайлав. Далавчит сүг сүүдрүүд дахин үзэгдээгүй боловч алсад хашгирах дуу нь байн байн гарч байв. Тэр дууг сонсоод зарим хүмүүс хоромхон зуурт айж ширвээтэн, дорой зарим нь айсандаа уйлж байлаа.

Фарамир дахиад л яваад өгөв.

- Бага ч гэсэн амардаг болоосой, тэр хоёр баатрын өмнөөс байлдаж байна. Өөрийнхөө өмнөөс, бас байхгүй болсон ахынхаа өмнөөс. Эзэн захирагч хүүгээ хайрлахгүй юм даа – хэмээн дайчид үглэж байв.

Олон хүн хойт зүг рүү ширтэн:

- Ристанийн морьт дайчид яагаад ирэхгүй байна аа? – гэгцгээнэ.

Фарамир өөрийн дур зоргоор яваагүй ажээ. Зөвлөлгөөнийг энэ өдөр эзэн захирагч тэргүүлсэн бөгөөд өөрийнхөө бодлоос ухарсангүй. Зөвлөл өглөө эрт хуралджээ. Нийтийн саналаар бол өмнө зүгээс ирэх аюулыг няцаах хүч байх нь байгаа, Ристанийн дайчид амжиж ирээ ч үү, үгүй ч үү, тиймээс ристаничуудыг ирэх хүртэл хотод байгаа бүх дайчдыг хэрмийн

ханануудаар тараан байрлуулах хэрэгтэй байлаа.

- Гэвч бид тийм их хөдөлмөрөөр босгосон их цайз Раммас-Экорыг байлдалгүй тавьж өгч болохгүй. Тэгээд ч дайсанд хохирол учруулахгүйгээр мөрнөөр гатлуулж болохгүй. Цайзыг бүслэхэд тэдэнд маш их хүч хэрэгтэй, тэд тийм хүчээ Каир-Андросаас хойгуур гатлуулж чадахгүй – тэнд нэвтэршгүй намаг байгаа, өмнө талаар нь ч гаргаж чадахгүй - тэнд Андуин өргөн, дайсанд завь хүрэлцэхгүй. Тэгэхлээр, дайснууд Осгилиат руу л явна, урьд нь Боромир тэдний довтолгоог тэнд няцааж байсан.

- Тэгэхэд дайсан биднийг зүгээр л түншиж үзсэн, харин одоо бол тэд хамаг хүчээрээ довтолно - гэж Фарамир анхааруулаад – бид нэг хүнээрээ арван дайсныг солилоо ч гэсэн дайснуудад энэ юу ч биш! Хүч дэндүү тэнцвэргүй байна. Дайсны хувьд мянган цэрэг хохирол биш, бидний хувьд зуун дайчин гэдэг асар их хохирол. Цайзаас Хот руу ухрах замд бүр ч аюултай, хэрэв дайсан бидний замыг хаавал биднээс нэг ч хүн үлдэхгүй.

- Каир-Андросыг яах болж байна? - гэж Имраиль ван асуув: - Осгилиатыг хамгаална гэдэг бол энэ арлыг ч хамгаална гэсэн үг, гэтэл арал зүүн талаас бэхлэлт байхгүй! Мустангримчүүд амжиж ирж болох л юм, үгүй ч байж магадгүй. Фарамирын ярьснаар бол Хар хаалганы цаана тоо тоймгүй олон дайсан бөөгнөрсөн байна. Тэд нэг чиглэлээр биш, тал талаас дайрч болно.

- Чононоос айвал ой руу бүү яв гэдэг - хэмээн Денэтор тэдний саналыг няцаагаад - Каир-Андрост хамгаалагчид байгаа, тэд нар арлыг хамгаална биз. Дахин хэлье. Пеленнорын цайзыг дайсанд өгч болохгүй, дайсныг саатуулалгүй мөрнөөр гатлуулж болохгүй, харин эзэн захирагчийн тушаалыг биелүүлэхэд эр зориг нь хангалттай хүрэлцэх жанжин тэнд хэрэгтэй.

Жанжингууд дуугарсангүй. Эцэст нь Фарамир хэлэв:

- Чиний тушаалыг эсэргүүцэх эрх мэдэл надад алга, эзэн захирагч минь. Боромирыг орлох хүн надаас өөр хэн байх билээ. Тиймээс цайз болон гармыг хамгаалах тушаалыг надад өгөх үү?

- Тийм ээ, өгч байна – гэж Денэтор баталлаа.

- Тэгвэл баяртай! - гээд Фарамир босч: - Хэрэв би эргэж ирдэг юм бол уур хилэнгээ өршөөл хайраар солиорой!

- Юутай эргэж ирэхээс чинь л шалтгаална даа.

Фарамирыг Гэндалф үдэн гаргаад:

- Чи ямар ч байсан өөрийгөө хайрла, гарцаагүй үхэл рүү битгий дайрч ор! Дайн дайнаараа, энэ хот чамгүйгээр тэсэхгүй. Эцэг чинь чамд хайртай, Фарамир, тэр энэ тухайгаа эргэж санах болно. Эргэж ирээрэй!

Ингээд Фарамир сайн дурынхнаас бүрдсэн жижиг отряд аваад дахин өмнө зүг хөдлөв. Минас-Тиритийнхэн хэрмэн дээрээсээ харанхуй руу ширтэж, юу ч харагдахгүй болохоор

дэмий л тэнд юу болж байгаа бол гэж таацгаахыг оролдож байлаа. Зарим нь урьдын адил умар зүг рүү ширтэж, Ристанийн Теоден ирж байна уу, үгүй юу гэж горьдоно.

- Тэр туслахаар ирэх л байгаа даа? Эртний холбоотноосоо урвахгүй биз дээ? хэмээн бие биенээсээ асууцгаана.

- Ирнэ ээ, - гэж Гэндалф хэлээд – Хожимдлоо ч гэсэн ирнэ. Гэвч өөрсдөө бодоод үз. Хүрэн сумыг түүнд гардуулснаас хойш цаанадаж л хоёр хонож байгаа, Эдорасаас Минас-Тирит хүртэл олон бээр газар шүү дээ.

Шөнө болохын өмнөхөн гарам дээрээс элч давхиж ирэв. Минас-Моргулаас шороо шиг олон дайсан гарч Осгилиат руу ойртож байна, тэдэнтэй асар том биетэй аймшигтай хэрцгий хородримчүүд үй олноор явж байна гэж илтгэв.

- Тэдгээрийг урьдын адилаар сүг сүүдрүүдийн Хар захирагч удирдаж явна, түүний өмнө үхлийн айдас явж байна – гэж элч мэдээлэв.

Энэ аймшигтай мэдээ бол Пин Минас-Тиритэд ирээд сонссон сүүлчийн аймшигт мэдээ байлаа. Унтаж амрахтай мантай юм болж, бүгдээрээ л Фарамир дайсны довтолгоог няцаах байх гэсэн ганц найдвартай үлдэв.

Дараачийн өдөр нь харанхуй өтгөрөөгүй боловч хүмүүсийн сэтгэл санааг улам л дарамталж, айдсаас салгахгүй байлаа. Муу мэдээ удалгүй ирлээ. Дайсны асар их хүч Андуиныг гаталжээ. Фарамир дайсны довтолгоог тогтоон барьсаар Пеленнорын цайз руу ухарч, харуулын цамхагуудад гарсан боловч дайсны хүч манайхаас наанадаж арав дахин олон байгаа ажээ.

- Цайзын энэ хэсэгт бидэнд хамгийн бэрх байна. Дайснуудаас тасарч холдоно гэж байхгүй, өсгий дараад л хөөгөөд байна – гэж элч хэлээд – Гарам дээр бид олон дайсныг устгасан, гэвч дайсан цөөрч байгаа шинж огт байгаагүй. Тэд эртнээс сайн бэлтгэсэн байна. Мөрний өмнөд эрэгт үй олон гатлага онгоц, сал нууцаар бэлтгэжээ. Мөрний ус ердөө ч харагдахгүй, мөрөн тэр чигээрээ өтчихсөн юм шиг л язганаад байсан. Хамгийн аймшигтай нь тэдний хар толгойлогч. Тэрний тухай сонсоход л хамгийн зоригтой дайчид хирдхийж байсан. Дайснууд өөрсдөө үхлийн аймшгаас ухаангүй айж байгаа учраас юу ч болж байсан урагшаа галзуу юм шиг улайран зүтгэж байна.

- Тэгвэл миний байх газар энд биш тэнд юм байна - гэж Гэндалф хэлээд тэр даруй харанхуй алсад мөнгөлөг гэгээ татуулан давхиж алга болов. Тэр шөнөжин Пин хэрмийн шагайвч дээр зогсоод өмнө зүг рүү ширтэж хонов.

Харанхуйд өглөөний хонх жингэнэхэд Пеленнорын талд, цайзын тэндээс гал улалзаж үзэгдэв. Харуулуудын түгшүүрт дуу хотод байгаа бүх дайчдыг тулаанд дуудлаа. Улаан дөл улам олширч, бүгчим харанхуйд бөглүү нижигнээн дуулдав.

- Цайз руу дайрч байна! Ханьг нурааж байна! Одоохон дайраад орно! – гэж эргэн тойронд шуугилдав.

- Фарамир хаана байгаа юм бол? Тэр үхэх ёсгүй, тийм юм байж болохгүй! - гэж Берегонд сандчин үглэнэ.

Эхний мэдээг Гэндалф авчирлаа. Тэр үд дундын хэрд шархдагсдаар дүүрэн тэрэгнүүдийг хамгаалсан хэдхэн дайчинтай ирэв. Харуулын цамхгийн дэргэд болсон тулалдаанаас олон шархтанг авч амжаагүй ажээ. Гэндалф шууд Денэтор руу оров. Эзэн захирагч Цагаан цамхгийн өндөр талбай дээрх хаан ширээний өргөөнд дөрвөн цонхоор ээлжлэн дөрвөн зүг рүү харж байх бөгөөд түүний цог шиг гялалзсан нүд эргэн тойрныг бүрхсэн харанхуйг нэвглэн бүгдийг үзэж байгаа юм шиг санагдана, түүний дэргэд Пин зогсчээ. Денэтор хойт зүг рүү байн байн харах бөгөөд заримдаа чих тавин чагнаж байгааг харахад эртний ямар нэг ид шидээр алсын хөндийд давхиж буй морьдын төвөргөөн сонсдож байх мэт.

- Фарамир ирэв үү? – гэж тэр асуув.

- Үгүй ээ, гэхдээ намайг түүнээс салахад тэр амьд мэнд бүрэн бүтэн байсан. Тэр ар талын отрядын хамт Пеленнорыг гаталсан дайсныг тогтоохоор үлдсэн, гэхдээ удаан тэсэхгүй болов уу. Дайсан үнэхээр асар их хүчтэй юм, миний айгаад байсан тэр дайсан өөрөө хүрээд ирж.

- Хар эзэн... Өөрөө хүрээд ирлээ гэж үү? – гэж Пин ордны дэг жаяг байтугай бүхнийг умартан хашгирав.

- Үгүй ээ, ноён Перегрин, одоохондоо ороод ирээгүй байна! - гэж Денэтор гашуунаар инээмсэглээд – Тэр бүх юм дууссан хойно миний амыг асуух гэж ирнэ. Харин тэр бодлоо өөрийнхөө төлөө бусдыг бидэнтэй байлдуулахаар явуулж байгаа юм. Миний эрхэм жижиг биет ноён минь, мэргэн ухаанаар дутаагүй бүх эзэн хаад ингэдэг юм. Тийм биш байсан бол би энэ цамхаг дээр сууж, ажиглаж, бодож, хүлээж, хөвгүүдээ золиосонд хаяж байх юм бэ? Би ч бас илдийг яаж эзэмшихээ мартаагүй шүү.

Тэр босч ирээд, урт хар өмсгөлийнхөө энгэрийг сөхөхөд түүний дотор хөө хуяг, мөнгөн чимэгт хар хуйтай, хоёр бариултай урт илд байхыг хараад Пин гайхав.

- Өтөлсөн биеэ үжрүүлэхгүйн тулд би олон жил хуяг дуулгатай унтаж байна – гэж тэр хэлэв.

- Нэг үгээр хэлэхэд Барад-Дурын эзэн эхлээд өөрийнхөө захиргаанд байгаа хамгийн хүчирхэг язгууртан үхдлүүдээ илгээлээ, тэгээд чиний хязгаарын цайзыг эзэллээ - гэж Гэндалф хэлээд – мянган жилийн өмнө тэр Ангмарын хаан байсан, ид шидтэн, дайчин байсан бол одоо сүг сүүдрүүдийн захирагч, Сауроны аймшигт зэвсэг болсон.

- За яахав, Митрандир минь, чамтай эн тэнцүүхэн хүч үзэх дайсан гараад ирж – гэж Денэтор хэлээд – Харин миний хувьд хар хүчний жанжин хэн бэ гэдгийг чамтай чамгүй мэдэж байна. Чи энэ тухай л мэдээлэх гэж ирсэн юм уу? Эсвэл тэрэнтэй тулалдах хүч хүрэхгүй учраас зүгээр л тулалдааны талбараас зугтааж ирсэн юм уу?

Гэндалф одоо хилэгнэнэ гэж айсандаа Пин овгосхийн очсон боловч тэгж айх хэрэг байсангүй.

- Хүч хүрэхгүй байж магадгүй, - гэж Гэндалф хэлээд - Би тэрэнтэй хүчээ үзэж байгаагүй. Хэрэв эртний домог үнэн бол, тэр дайчин эрийн гарт үхэхгүй, гэхдээ гэхдээ түүний хувь заяа мэргэдээс нууц. Тэгээд ч тэр аймшигийн эзэн хараахан ирээгүй байна. Чиний ярьсан мэргэн ухаанаар бол, тэр ухаангүй боолуудыг урдаа хөөж явна. Би тулалдааны талбараас зугтааж ирсэнгүй ээ. Би эмчилж эдгээгээд эгнээнд нь оруулах боломжтой шархтнуудыг л хамгаалж ирсэн. Раммас-Экорыг тал талаас нь дэлбэлж, хэмхэлж байна. Моргулийн цэрэг одоохон нөмрөөд орж ирнэ. Би чамд тулалдаан одоо энэ цайзад болно гэж чамд хэлэхээр ирсэн юм. Морьт дайчдыг гадагш гаргах хэрэгтэй байна, бидний бүх найдвар тэдэнд л байна. Яагаад гэвэл дайсан морин цэрэг цөөтэй юм байна. Тэдний морьт цэрэг хараахан ирээгүй байна.

- Манайд ч гэсэн морьт дайчид цөөхөн. Ристанчууд одоо хүрээд ирвэл ч! – гэж Денэтор хэлэв.

- Түүнээс өмнө энд өөр зочид ирж байна. Каир-Андросаас зугатаж ирсэн хүмүүс цайз дээр тулалдаж байна. Арал дайсанд эзлэгдсэн. Дайсны хоёр дахь хүч Хар хаалганаас гарч баруун хойт талаас дайрч байна.

- Чамайг муу мэдээ дуулгах дуртай гэж ярьцгаадаг нь үнэн бололтой Митрандир, гэвч чи надад мэдээ авчирсангүй. Би энэ бүхнийг өчигдөр оройноос хойш мэдэж байсан юм. Морьт дайчдыг гаргах талаар би аль хэдийн бодсон. Доошоо бууцгаая.

Цаг явсаар, тэргүүн эгнээний анги ухарч байгаа нь хэрэм дээрээс харагдаж байв. Эхлээд хэсэг бусгаараа тарж, ядарч туйлдсан, шархадсан хүмүүс цуван ирцгээж, зарим нь ухаан жолоогүй гүйж ирэв. Дорно зүгт гал улам олшрон тал дээгүүр наашлан мөлхөж байх шиг харагдана. Талд байгаа байшин хашаанууд дараа дараалан шатаж, гал могой мэт мушгиралдан наашилж байв.

- Наашилж байна. Заставыг эзэлчихэж. Хэрмийг сэтлээд дотогш орох гэж дайрч байна. Бамбар бариад дайрч байх шиг байна. Манайхан хаана нь байна аа? – гэж хүмүүс дүнгэнэлдэнэ.

Орой болж, харанхуй өтгөрсөн тул хамгийн сайн хараатай дайчин ч гэсэн хэрэм дээрээс хараад хараад юу ч олж харахгүй болов. Зөвхөн галан гол улам хурдан урсан наашилж байна. Хотоос нэг бээрийн зайд хүмүүс гарч ирэв. Тэд замбараагүй тарж гүйсэнгүй, эгнээгээ алдахгүй явж байгааг бодвол дайчид бололтой. Хэрэм дээр байгаа хүмүүс амьсгаа даран тэднийг харж байлаа.

- Фарамир ирж байх шиг байна. Тэрэнд хүмүүс ч, морьд ч захирагддаг. Одоохон ороод ирнэ, харж л байгаарай - гэгцгээв.

Тэд хүрч ирэхэд дөрөвний нэгэн бээр үлдлээ. Явган дайчдын араас арын хамгаалалтын морьт дайчид давхин гарч ирэв. Тэднээс хориод нь л амьд гарсан бололтой. Тэд жолоогоо эргүүлж дахиад л галан урсгалын өөдөөс дайрлаа. Гэнэт чих дөжрөм аймшигт орилоон хадав. Дайсны морьт цэрэг үүл манан мэт нөмрөн орж ирлээ.

Тэд нэгэн их галан далай болон нийлж, бамбар барьсан орхууд, улаан туг барьсан мордорууд галзуу дуугаар орилолдон ухарч байгаа хүмүүсийг гүйцэж, урд нь гарав. Харанхуй тэнгэрээс

далавчит сүг сүүдрүүд зүрх чичрүүлэн аймшигт дуугаар чарлан ухрагсад руу дайрлаа.

Жагсаал сарниж, айдаст автсан хүмүүс тал тал тийш таран гүйж, зэвсгээ хаяж, газарт нам хэвтэж байв.

Тэгтэл хэрэм дээрээс бүрээ цангиналаа. Денэтор морьт дайчдыг гаргах тушаал өгчээ. Хотод байсан бүх морьт дайчид хэрмийн хаалганы орчимд энэ дохоиг хүлээж ядаж байсан бөгөөд дохио сонсонгуут нэгэн зэрэг ухасхийн дайчин уриагаа цууриатуулан талыг бүрхсэн дайсны өөдөөс морины хурдаар довтоллон оров. Тэдний өмнө Дол-Амротын баатар вангууд Имраилийн мөнгөн хунтай хөх тугаа дэрвүүлэн хурдалж байна.

- Амрот Гондорт туслахаар ирлээ! Амрот, Фарамир! – гэж хэрэм дээрээс хашгиралдав.

Тэд ухарч байгаа дайчдын хоёр талаар өнгөрөн давхиж, дайсны урсгал руу дайран ороход нэгэн мөнгөн цагаан морьтон хурц гэрэл цацруулсан очир өндөрт өргөн тэдний өмнүүр орлоо.

Дайснууд мэгдэн сандарч, аймшигтай орилоон нь чимээгүй боллоо. Тэдний толгойлогч - цагаан гэрлийг унтраагч хараахан алга байв. Мордорын махчингууд оволзон дайрч байснаа гэнэт түүдэг гал хүчтэй салхинд унтрах мэт бутран замхрав.

Ухарч явсан Гондорын дайчид тэр даруй эгнээгээ эмхлэн эргэж, дайчин уриагаа цуурайтуулан дайрлаа. Ингээд зугтагсад хоромхон зуурт анчид болон хувирч, ухралт довтолгоон болов. Өргөн тал орхууд болон хородримүүдийн хүүрээр дүүрч, эзэнгүй бамбарууд унтарлаа. Морьт дайчид улам урагшлан цавчиж, гишиглэн цаашлав.

Гэвч Денэтор давших тухай бодоогүй байлаа. Хэдийгээр дайсныг зогсоож буцаан хөөсөн боловч дорноос дайсны асар их хүч наашилж байлаа. Дахиад л бүрээ цангинаж, Гондорын морьт дайчид жолоогоо эргүүлэхэд тэдний хамгаалалтын дор Фарамирын дайчид жагсаалаа эмхлэн нуруу цэх, толгой дээгүүр хэрмийн хаалгаар орж ирэв. Минас-Тиритийн хамгаалагчид тэдэнд баяр хүргэн түрхрэлдсэн боловч маш гунигтай байлаа. Фарамирын дайчдын гуравны нэг гаруй нь алга байв. Тэр өөрөө ч алга.

Дайчид хот руу орж, хамгийн сүүлд Дол-Амротын баатар вангууд орж ирэхэд Имраилийн ван өөрийнхөө угсаа нэгтэн, Деноторын хүү Фарамирын биеийг гар дээрээ өргөн орж ирэв.

- Фарамир! Фарамир! – хэмээн хашгиралдаж байснаа орь дуу тавин эхэр татах дуун хотоор нэг хадлаа. Тэр хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй байв. Түүнийг тахиралдсан урт замаар өгсүүлэн эцэгт нь авчирлаа.

Цагаан морьтны довтолгооноос амь зулбан харанхуйд нуугдсан нэг дайсан хородримүүдийн толгойлогчтой халз тулалдаж байсан Фарамир руу хорт сум харважээ. Дол-Амротын баатар вангууд түүний биеийг аль хэдийн далайсан хүрэн илднүүдээс аварчээ.

Имраилийн ван Фарамирыг Цагаан цамхагт оруулж ирээд.

- Таны хүү агуу их гавьяа байгуулаад эргэж ирлээ эзэнтэн минь – гэж хэлээд өөрийн нүдээр харсан үйл явдлыг ярьж өглөө.

Гэвч Денэтор түүний үгийг сонссон ч үгүй, таг дуугүй босч ирээд хүүгийнхээ нүүр рүү харав. Дараа нь өргөөнд ор дэр засч Фарамирыг хэвтүүлэхийг тушаагаад, бүгдийг тараав. Өөрөө цамхагийн орой дээрх нууц байр руугаа орсон бөгөөд нарийн цонхонд нь гэрэл асч, хэсэг улалзсанаа унтрахыг олон хүн харжээ. Тэгээд Денэтор дахин доош бууж, Фарамирын дэргэд хэсэг суухад эзэн захирагчийн царай хүүгийнхээ царайнаас ч үхэнг цагаан байлаа.

Дайснууд хотыг бүсэлж, Раммас-Экорыг үнсэн товрог болгон Пеленнорыг бүрэн эзэлжээ. Хаалга хаахаас өмнө амжиж ирсэн умард заставын хамгаалагчид сүүлчийн мэдээг авчрав. Тэд Анориэнаас Ристани орох замыг хамгаалдаг дайчдаас амьд үлдсэн хэдэн дайчин байв. Тав хоногийн өмнө Гэндалф, Пин хоёрыг нэвтүүлсэн харуулын ахлагч Ингольд тэднийг удирдан иржээ. Тэгэхэд тэнгэрт нар гэрэлтэж, хүмүүсийн зүрхэнд итгэл найдвар бөхөөгүй байсан билээ.

- Мустангримчүүдийн талаар ямар ч сураг ажиг алга. Ристаниас нэг ч хүн үзэгдээгүй. Хэрэв тэд одоо нааш ирэх юм бол өөрсдөд нь л муу юм болно. Дайсан тэднээс урьтсан. Дайсны шинэ хүч мөрний цаанаас Каир-Андрос руу явж байгаа тухай мэдээ бидэнд ирсэн. Тоо томшгүй олон дайсан. Бамбай, дуулган дээрээ нүдтэй шороо шиг олон орхууд, бид урьд өмнө харж үзээгүй хачин амьтад ч байгаа. Гномууд шиг намхан, чийрэг зузаан, хууз сахалтай юмнууд байна лээ. Бодвол дорнын ямар нэг зэрлэг бөглүүд хязгаарынх биз. Хойт замыг хаасан, Анориэн руу асар их хүч илгээсэн. Мустангримчуудад наашаа нэвтрэх зам байхгүй.

Хаалганууд бүгд хаалттай байлаа. Хэрмийн харуулынхан тээр доор дайснууд шөнөжин тариа ногооны талбай, төгөл шатааж, шархдагсдыг гүйцэж, алагдагсдын цогцсоор тоглож байгааг сонсч байлаа. Мөрний цаанаас хичнээн дайсан нэмэгдэж ирснийг харанхуйд мэдэх боломж байсангүй, харин өглөө харахад урд шөнө ирсэнээс ч олон дайсан нэмэгдсэн нь илт байв. Хэрмийн дэргэдээс цааш нүдний хараа хүрэх газарт хуйхлагдсан хар талд хар, хүрэн майхнууд зайгүй шавааралдаж, газар тэр чигээрээ өгчихсөн юм шиг үй олон юм язганаж байлаа.

Сум хүрэх зайнаас арай цаахна орхууд язганан, газар ухаж байна. Ухсан газартаа яаж гал үүсгээд байгааг бүү мэд, заавал гал асааж байна. Тэр гал нь өдөржин огт унтарсангүй. Хэрмийн хамгаалалтынхан яаж ч чадахгүй, дэмий л ажиглаж байв. Галаа асаангууд баахан орхууд чулуу харвагч авчран байрлуулж байна. Хотод тийм төхөөрөмж байхгүй, байгаа нь тийм хол тусгалгүй байлаа.

Гэвч бүслэгдэгсэд эхлээд шоолон инээлдэж байв. Тэр хачин том багажнууд эхлээд тэднийг айлгасангүй. Хотын энэ өндөр, зузаан хэрмийг нуменорчууд ид мандан бадарч байх үед гайхамшигт барилгачдаараа бариулсан билээ. Ортханкийн адил гилгэр хар чулуун гадаргуу нь галд шатахгүй, ганд ч дийлдэхгүй, хэрмийг бутлах ганцхан зам бол түүний дорх газрыг сэгсэрч, хагалах хэрэгтэй байлаа.

- Дайсан өөрөө хүрээд ирсэн ч биднийг амьд байхад манай хот руу орж чадахгүй – гэж гондорчууд ярьцгааж байв.

Гэвч зарим нь.

- Биднийг амьд байхад уу? Бид удаан тэсэх юм уу? Дайсанд энэ дайн эхэлснээс хойш нэг ч хэрэм тэсгээгээгүй зэвсэг бий. Тэр бол өлсгөлөн. Бүх зам хаалттай байгаа. Ристаничууд ч ирэхгүй шинжтэй боллоо.

Гэвч дайснууд автагдашгүй бат бэх хэрмийг чулуугуур харваж дэмий цаг алдсангүй, тэднийг дээрэмчдийн бүлгийн толгойлогч юм уу, орхуудын толгойлогч удирдаагүй бололтой, Мордорын хамгийн заналт дайсны эсрэг тулалдааныг эрх мэдэл, өшөө хорсол дүүрэн ухаантай толгой удирдаж байгаа нь илт. Дайснууд орилж хашгиралдан, хараал зүхэл тавьж, урт гинж, өндөр өргөгч чихруулан оволзсоор асар том харвагчууд босгож, тэр даруйдаа л хэрмийн хана давуулан урьд өмнө үзэгдээгүй хачин сумнууд харваж эхлэв. Тэр сумнууд нь газарт бөглүү чимээ гарган хүндээр унахдаа гал дөл цацруулан дэлбэрч байлаа. Тийнхүү хотын дотор ид шидийн хүчээр үүссэн мэт их гал түймэр дүрэлзэн шагайвчийн харуулуудаас бусад нь бүгдээрээ тэр түймрийг унтраахаар ухасхийв. Гэтэл дайснууд тэдний дээрээс түрүүчийнхээс өөр, маш жижиг сумнууд харваж эхэллээ. Мөндөр мэт олноор бууж байгаа тэр сумнууд гудамж талбайгаар өнхрөлдөв. Тэр сумнууд юу болохыг мэдсэн хатан зоригт эрэлхэг дайчид хүртэл хэнээс ч айж ичилгүйгээр орилолдон уйлж байв. Учир юун гэвээс тэр сумнууд нь Раммас-Экорыг хамгаалахын төлөө, Осгилиатыг хамгаалан тулалдаж амь үрэгдсэн дайчдын толгой байжээ. Эвдэрч, хэв дүрсээ алдсан толгой бүхэн дээр Дайсны үл анигч нүдийг зурсан, тэгсэн мөртөө хэний толгой болох нь танигдаж байсан учир хот даяар аймшигт автав. Дөнгөж саяхан дайчдын жагсаалд цог золбоотой алхалж, тариа ногооны талбайд хөлсөө урсгаж, уулын ногоон хөндийгөөс ургацын баярт ирдэг байсан тэр дайчдыг таниад хүмүүсийн уур хилэн дүрэлзлээ.

Гэвч цусанд шунасан дайснуудын өөдөөс хэрмийн ханан дээрээс нударга зангидан занаж зүхээд яах билээ. Дайснууд өрнөдийн хэлийг ойлгох ч үгүй, ерөөсөө тэд хэл гэж байхгүй, архирч, гуйгалж, тагнай ташиж, улихаас өөр хэлгүй амьтас байлаа. Дайсны жанжин бүслэгдсэн хотынхныг өлсгөлөнгөөр туйлдуулах гэж хугацаа алдалгүй айдас, цөхрөл хоёроор унагах гэж төлөвлөжээ.

Дахиад л хар сүгнүүд нисэн ирж, зүрх салгалтал орилолдон, амжилтандаа сагсуурсан Хар эзний үхэл таригч өшөө хорслыг тарааж байв. Хар сүгнүүд хотын дээгүүр үхдлийн сэг хайсан тас мэт эргэлдэцгээнэ. Нүдэнд харагдахгүй, сумны тусгалд орж ирэхгүй мөртөө хаа сайгүй эргэлдэн, тэсэхийн аргагүй жихүүн дуугаар орилолдоно. Энэ байтугай ихийг үзсэн дайчид хүртэл нөмөрсөн аюулаас зугтаах мэт нүүрээ даран нам хэвтэж, хөл дээрээ зогсч байгаа зарим нь мэдээ алдарсан гараасаа зэвсгээ унаган, ухаан мэдрэл нь хар айдсаар дүүрч, байлдаж тулалдах тухай огт бодолгүй, хурдан нэг газар нуугдаж, түргэхэн үхэхийн хүслэн болж байв.

Фарамир Цагаан цамхгийн өргөөнд нам хэвтэж, хамаг бие нь чичрүүдэст автан, хэн нэгэн түүнд “Чи үхэж байна” гэж хэлэхэд гудамж талбай, хэрэм дээр байгаа хүмүүс бүгдээрээ “Чи үхэж байна” хэмээн давтаж байлаа. Эцэг нь дайн байлдааныг ор тас мартаад, дэргэд нь сууж, хүүгээ нүд салгалгүй ширтэж байв.

Пиний хувьд орхуудад амьдаараа баригдсан бол үүнээс арай хөнгөн байхсан гэж бодогдов.

Тэр эзэн захирагчийн дэргэдээс салах ёсгүй, цаадах нь түүний байгаа эсэхийг мэдээ ч үгүй мэт боловч дэргэд нь зогсоор, аймшгийн айдсаас яаж ийгээд бодлоо салгаж, харанхуй өргөөний үүдэнд хэдэн цаг зогсов. Заримдаа тэр Денэтор руу харахад, үл нугарах бардам эзэн захирагч нүдний өмнө хөгширч, саруул тунгалаг ухаан нь бүүдгэрч байх шиг санагдана. Уй гашуу түүнийг ийнхүү сөхрүүлж байна уу, гэмшил нь сөхрүүлж байна уу, бүү мэд. Түүний амьдралд анх удаа хацар дээгүүр нь нулимс бөмбөрч байгааг харахад түүний яаж ч уурлан хилэгнэж байхыг харахаас хэцүү байлаа.

- Битгий уйл даа эзэн минь, амь орох байлгүй дээ, та Гэндальфаас асуусан уу? – гэж Пин бувтнахад.

- Тэр илбэчнийхээ нэрийг бүү дурс! Тэрний тэнэглэл биднийг сүйрүүллээ. Дайсан юуг эзэмдсэнийг чи мэдэж байна уу, одоо тэрний хүчин чадал зуу дахин нэмэгдсэн. Тэр одоо бидний бүх санааг ил тод мэдэж байгаа, юу ч хийгээд нэмэргүй, тэртэй тэргүй өнгөрсөн.

Би хүүгээ урамшуулаа ч үгүй, үдэж гаргаа ч үгүй, ямар ч ашиггүй үхэл рүү явуулсан, одоо энд цус нь хордчихоод хэвтэж байна. Үгүй шүү, үгүй, хэн яаж хүссэнээрээ байлдаг, миний удам тасарлаа, би Гондорын сүүлчийн эзэн хаан.

Энэ орныг харц ардууд захирдаг юм байгаа биз, нэгэн цагт агуу их байсан ард түмний хөөрхий үлдэгдлүүд толгой дараалан баригдах хүртлээ ууланд нуугддаг юм байгаа биз.

Хаалганы цаана хүмүүс үймэлдэж, эзэн захирагчийг дуудлаа.

- Үгүй, би доош буухгүй. Миний байх газар хүүгийнхээ дэргэд. Үхэхийнхээ өмнө нэг үг хэлэх ч юм бил үү. Энэ үхэж байна. Та нар хэндээ захирагдана, дураараа бол, найдах юм юу ч үгүй болсон Саарал галзууд захирагдсан ч яадаг юм бэ. Би эндээс босохгүй – гэж тэр хэлэв.

Ийнхүү Гэндальф Гондорын нийслэлийн хамгаалалтыг мөхөх сөнөхийн даваан дээр нь удирдах хэрэгтэй боллоо. Түүний очсон газар бүрт хүмүүсийн зүрхэнд итгэл найдвар сэргэж, далавчит сүгнүүдээс айх айдас зайлж байлаа. Тэр хэрмийн дээгүүр зогсолтгүй явж байхад үүнтэй хамт Дол-Амротын эзэн хуяг дуулгаа гялалзуулан дагаж явав. Дайчид тэр хоёроос нүд салгалгүй хоорондоо шивнэлдэнэ.

- Эртний домог үнэнийг өгүүлжээ. Эдний цусанд эльфийн цус урсч байна, нэгэн цагт Нимродэль өөрийн ард түмэнтэйгээ тэнд амьдарч байсан нь дэмий хэрэг биш байна.

Хэн нэгэн нь “Нимродэлийн тухай дуу” юм уу, аль эрт цагт Андуины хөндийд зохиогдсон өөр нэг дууг аялав.

Гэвч Гэндальф болон Имраиль ван явж одоход дахиад л галзуу мэт орилоон зүрх зүсч, чих дөжүүлэн Гондорын дайчдын эр зориг суларч байлаа. Аймшгаар дүүрсэн харанхуй өдөр ийнхүү дуусч, шөнийн сохор харанхуй нөмөрлөө. Нэгдүгээр давхарт түймэр дүрэлзэн, унтраах хүн ч байсангүй. Гадна хамгаалалтын хүчинд ухрах зам таслагдаж, ихэнх нь хоёр дахь давхар руу орсон байв.

Алсад, гарман дээр дайснууд гүүр тавьж, түүгээр өдөржин ачаа хөсөг цувж байв. Эцэст нь, шөнө дунд гэхэд довтолгоон эхлэхэд бүх юм бэлэн болж, эхний мянгатууд тусгайлан гаргасан замаар гал түймэр дундуур нэвтрэн орж ирлээ. Тэд шахцалдаж, шавааралдан зүтгэсээр сум хүрэх газарт орж ирэв. Тэднийг гал түймэр гэрэлтүүлж байсан болохоор алдаж харвах боломжгүй байв. Гондор эртнээс мэргэн харваачдаараа алдартай билээ. Гэлээ ч гэсэн цөөхөн сум нисэн ирж байсан учир ард нуугдсаар байсан Мордорын жанжин бүслэгдсэн гондорчууд санаа сэтгэлээр унасан байна гэж дүгнээд цэргээ дайралтад оруулав.

Гондорын хааны өргөөний үүдэнд дахиад л элч нар ирж, эзэн захирагчтай уулзах гэсэн тул Пин тэднийг орууллаа. Денэтор Фарамирын нүүрнээс нүдээ түр салгаж тэдэн рүү дуугүй харав.

- Доод давхар бүхэлдээ галд автлаа. Та ямар зарлиг гаргахсан бол эзэн минь? Та Гондорын эзэн захирагч хэвээрээ байгаа. Зарим хүмүүс хэлж байна. Митрандирын тушаалыг биелүүлэхгүй - тэгээд байлдааны байраа орхин хэрэм дээрээс явж байна.

- Яах гэж? Яах гэж тэр тэнэгүүд байраа орхин зугатаж байгаа юм бэ? – гэж Денэтор хэлээд – Тэртэй тэргүй шатаж үхэхээс хойш. Буцаад гал руугаа ор гэж хэл! Би юу? Би хамгийн түрүүчийн оршуулгын гал руу орно. Тийм ээ, хамгийн түрүүчийн! Өвөг дээдсийнхээ бунханд Денэторт ч, Фарамирт ч зай байхгүй. Үхсэний дараа тухлана гэж бидэнд байхгүй. Бид өрнөдөөс нэг ч хөлөг хөвж ирээгүй байх үеийн хаад шиг үнс болно. Бүх юм дууссан. Өрнөд ялагдлаа. Явж гал руугаа орцгоо!

Элч нар эзэн захирагчид мэхийж ёсолсонгүй, таг дуугүй гарцгаав. Денэтор Фарамирын гал мэт халуун гарыг тавиад бослоо.

- Гал түүнийг залгиж байна, дотор талаас нь залгиад дуусч байна – гэснээ Пинд дөхөж ирээд, дээрээс нь доош харж. - Баяртай! Паладаниний хүү Перегрин минь баяртай! Чиний алба богинохон байлаа, одоо дуусч байна. Одоохон дуусна, гэхдээ би чамайг яг одоо явуулахгүй. Яв, яаж л бодно, түүгээрээ үх. Хэнтэй ч хамаагүй, хаа ч хамаагүй үх, солио ухаанаараа чамайг үхэл рүү авчирсан илбэчинтэйгээ ч хамаагүй үх. Миний зарц нарыг дуудчихдаад эндээс гар, баяртай! гэв.

- Би чамтай салах ёс хийхгүй ээ, эзэн минь - гэж Пин өвдөг сөхрөн хариулаад, гүн нойрноос гэнэт сэрсэн мэт босон харайж эрх мэдэл ихт өвгөний нүд рүү эгц хараад

- Чиний тушаалаар би гарна, гэхдээ би Гэндальфтай уулзах маш их чухал хэрэг байна. Тэр бол солиот биш, хэрэв тэр үхэхээр шийдээгүй бол би бас түүнд хэрэг болно. Харин чи амьд байгаа цагт би өөрийнхөө андгай тангараг болон чиний албанаас чөлөөлөгдөхгүй. Хэрэв дайснууд энэ цайзыг эзэлдэг юм бол би чиний дэргэд тулалдаж, надад үзүүлсэн хүндэтгэлийг дааж магадгүй юм.

- Өөрийнхөө бодсоноор л шийд, эрхэм жижиг биет минь, миний амьдрал дууссан гэж би хэлсэн, зарцыг маань дууд – гэж Денэтор хэлэв.

Тэгээд дахин Фарамир руу очлоо.

Пин эзэн захирагчийн зарц бүрэн зэвсэглэсэн зургаан өндөр чийрэг дайчинг авчрав. Тэд их л айсан царайтай байлаа. Гэвч Денэтор Фарамирыг дулаан хучаад ортой нь мөрөн дээрээ өргөж гарахыг тайвнаар тушаав.

Зарц нар тушаалыг биелүүлж Фарамирыг ортой нь өргөн өргөөнөөс гарч, үхэж байгаа түүнийг доргиохгүйн тулд нэгэн хэмээр удаан алхлан явахад Денэтор тэдний араас очироо тулан явж, гашуудлын цувааны сүүлд Пин оров.

Тэд Цагаан цамхгаас харанхуй руу ороход, дээрээс нөмрөн дарсан хар үүлийг гал түймрийн хүрэн улаан дөл долоож байлаа. Тэд нэг өргөн хашааг гатлаад Денэторын тушаалаар хатсан Модны дэргэд зогсов.

Шөнийн нам гүмийг зөвхөн алсад болж байгаа тулалдааны чимээ л эвдэж, доош гудайсан нүцгэн мөчрүүдээс унах усан дуслууд нуурын харанхуй мандал дээр гунигтайяа под подхийж байлаа. Тэд цайзын хаалгыг өнгөрөхөд харуул араас нь гайхаж түгшсэн харцаар ширтэж хоцров. Баруун тийш эргэж зургадугаар давхрын арын хананд байгаа хаалганд тулж очлоо. Энэ хаалгыг Фен-Холлен буюу Түгжээтэй хаалга гэж нэрлэдэг, учир нь зөвхөн оршуулга болоход л нээдэг, зөвхөн эзэн захирагч болон гашуудлын бараан өмсгөлт оршуулгын албатууд л ордог ажээ. Хаалганы цаанаас зам тахирлан уруудаж, Гондорын эртний эзэн хаадын бунхнууд руу хөтөллөө.

Хаалганы дэргэд нэг жижигхэн байшин байх бөгөөд тэндээс айж сандарсан манаач дэнлүү барьсаар гарч ирэв. Денэторын тушаалаар тэр хаалгыг нээхэд хаалга чимээгүйхэн нээгдлээ. Манаачийн дэнлүүг аваад дэнлүүний гэрэлд дөнгөж үзэгдэх төдий байгаа эртний хананууд болон олон баганатай хашлагуудын дундуур муруйж тахирласан замаар уруудлаа. Тэдний удаан алхаа бөглүүхэн цууриалж, улам улам доошилсоор эцэст нь Рат-Динен буюу Аниргүй гудамжинд гарч ирлээ. Тэнд тэднийг бүдэгхэн гэрэлтэх ганжирууд, хоосон хана, үхсэн хаадын хөшөө баримал бүхий Эзэн хаадын бунхан угтлаа. Тэнд ачаагаа буулгав.

Пин ийш тийш мэгдэн харж, нуман хаалгатай тасалгаанууд бүхий уужим танхимд орж ирснээ ойлгов. Дэнлүүний бүдэгхэн гэрэлд эргэн тойрны хананд тэдний сүүдэр аварга амьтад шиг сүүдэгнэнэ. Эгнүүлэн босгосон гантиг ширээнүүд дээр гараа цээжиндээ зөрүүлж, хатуу дэрэн дээр дэрлэсэн талийгаач нар мөнхийн нойрондоо умбан байна. Нэг талд нь хоосон өргөн ширээ байна. Денэторын дохиогоор тэр ширээн дээр Фарамирыг тавиад, эцэг нь түүний дэргэд нэг хөнжилд орж хэвтэв. Зарц нар нь толгой гудайн зогсоцгоов.

- Бид энд хүлээж байя - гэж Денэтор аяархан хэлээд. - Хойтхыг хөтлөгчдийг битгий дуудаарай, харин хуурай түлээ ахиухан авчирч, бид хоёрыг тойруулж овоол, тос асгаад бамбар бэлтгэ. Намайг тушаамагц асаагаарай. Баяртай!

- Таны болгоосноор би явлаа, эзэн минь! – гэж Пин хэлээд бунхны бүгчим танхимаас ухаан жолоогүй гүйж гарав. “Хөөрхий Фарамир! Гэндальфыг даруйхан олох хэрэгтэй. Хайран Фарамир! Тэрнийг шатаах биш, эмчлэх хэрэгтэй. Одоо би Гэндальфыг хаанаас олно оо? Мэдээж дайны хамгийн гол гал дунд байгаа, үхэж байгаа болон солиорсон хүний төлөө санаа зовох ямар ч завгүй байгаа биз” – гэж тэр бодлоо.

Хаалгын дэргэд харуулд гарсан дайчинд хандаж.

- Танай эзэн захирагч өөрийн ухаанаа алдсан байна. Та нар битгий яараарай! Гол нь Фарамирыг амьтай байгаа цагт шатаахаа азнаарай. Гэндальф ирээд учрыг нь олно – гэж хэлэв.

- Минас-Тиритийн эзэн хэн юм бэ? Эзэн захирагч Денэтор юм уу, Саарал тэнэмэл юм уу? – гэж харуул сөргөж асуув.

- Миний бодлоор бол Саарал тэнэмэл, эсвэл хэн ч биш – гэж Пин хэлээд муруй тахир замаар байдгаараа хурдлан гүйсээр нээлттэй байгаа Түгжээт хаалганд хүрч, алмайрсан харуулын өмнүүр харайн өнгөрч, гол цайз хүртэл тэр чигээрээ гүйлээ. Харуул түүнийг дуудахад Берэгондын дууг танив.

- Хаашаа хурдалж байна, ноён Перегрин?

- Митрандирыг хайж байна.

- Бодвол эзэн захирагчийн тушаал биз дээ, чамайг саатуулах нь зохисгүй боловч хоёр үгээр хэлээд өгөөч, юм асууя - гээд Берэгонд, - Юу болоод байна аа? Эзэн хаашаа явсан бэ? Би дөнгөж сая халаа авч байна, Фарамирыг Түгжээтэй хаалга руу авч орсон гэж надад хэллээ, Денэтор ард нь дагаж явсан гэх юм.

- Аваад орсон, тэр хоёр одоо доор, Бунханд байгаа - гэж Пин батлав. Берэгонд нулимсаа нуух гэж тонгойлоо.

- Тэр үхэж байна гэж би сонсон, тэгэхлээр үхсэн юм байна л даа.

- Арай ч үгүй, хараахан үхээгүй байна. Тэрнийг аварч болно гэж би бодож байгаа шүү. Харин Берэгонд минь хот тэссээр л байна, гэтэл эзэн захирагч бугаад өгчихлөө - гээд болсон явдлыг хам хум ярьж өгөөд. - Би яг одоо л Гэндальфыг олох хэрэгтэй байна – гэв.

- Эндээс олдохгүй дээ, доор л байгаа байх.

- Би хаана байгааг нь мэдэж байна, эзэн намайг чөлөөлсөн. Сонсч бай, Берэгонд, ямар нэг юм болвол чи оролцоорой, тэгэхгүй бол бодохоос ч айж байна.

- Гол цайзын харуул эзэн захирагчийн тушаалгүйгээр харуулын байраа орхихыг хатуу хориглосон байдаг юм.

- За яахав, тэр тушаал чинь Фарамирын аминаас үнэтэй юм бол яая гэхэв... - гэж Пин хэлээд.
- Эзэн захирагч өөрөө солиорчихоод байхад юуны чинь тушаал мушаал. Би гүйлээ, амьд гарвал эргээд ирнэ.

Тэгээд гудамжаар гадна хэрэм рүү гүйв. Түүний урдаас түймэр дундаас гарч ирсэн хүмүүс гүйлдэж, зарим нь хамгаалагчийн өмсгөлтэй бяцхан хүнийг хараад дуудсан боловч тэр эргэж ч харсангүй. Эцэст нь хоёр дахь хаалгыг өнгөрөхөд ханануудын хооронд улаан гал дүрэлзэж

байв. Гэвч яагаад ч юм чив чимээгүй. Тулалдааны чимээ, орилолдоон, зэвсгийн хангинаан аль нь ч дуулдсангүй. Гэтэл гэнэт зүрх зүсэм муухай дуу аянга мэт тасхийж, дараа нь чих дөжрөм цууриа татуулсан лужир хүнд цохилт сонсдов. Тэсэхийн аргагүй айдсаас Пиний шөрмөс татах шиг болсон ч тэр Их хаалганы өмнөх өргөн талбай руу шагайж харав. Харангуутаа хоромхон зуурт хөшиж орхилоо. Тэр Гэндальфыг харсан боловч гэдрэг үсэрч, харанхуй буланд нуугдав.

Шөнө дундаас ерөнхий довтолгоо үргэлжиллээ. Энд тэндгүй бөмбөр нижигнэж, хэрмийн хойт болон өмнө талыг дайсны олон мянган цэрэг бүслэн дайрч байв. Бүрэнхий улаан туяан дунд байшин шиг нүсэр том юмнууд ургашилж байсан нь хородримийн мумакууд гал түймрэн хөшигний цаанаас бүслэлтийн цамхгууд болон хэрэм нураагч авчирч байсан ажээ. Дайснууд ямар ч эгнээ жагсаалгүйгээр дайран бөөн бөөнөөрөө алагдаж байлаа. Бүслэлтийг удирдагч цайзын хамгаалалтын байдлыг тандах, гондорчуудын хүчийг сарниулахын тулд үй олон боолуудыг үхэл рүү хөөн оруулж байв. Тэр их хаалган дээр хамгийн хүчтэй цохилтоо хийхээр төлөвлөжээ. Маш зузаан ширмээр барьж, гангаар найдвартай бэхэлсэн их хаалганы эргэн тойронд ганхашгүй цамхгууд хамгаалж байсан ч энэ хаалга автагдашгүй аварга цайзын цорын ганц эмзэг газар нь байлаа.

Бөмбөрүүд дахин чангаар нижигнэв. Энд тэндгүй галын дөл цоролзон, бүслэлтийн машинууд талаар мөлхөж, тэдгээрийн хооронд зуу гаруй фут урт харвагч цамхгууд зузаан гинжин дээрээ ганхан ойртоно. Тэдгээрийг Мордорын харанхуй дархны газруудад олон жил давтжээ. Хар гангаар хийсэн аймшигт үзүүр нь амаа ангайсан чонын хоншоор дүрстэй, дээр нь хар шидийн тарни цохижээ. Тэр аймшигт харвуулыг эртний газрын гүний хүнд хар лантууны нэрээр Гронд гэж нэрлэсэн байна. Тэрнийг тойрон аварга том араатнууд, орхууд чихэлдэн дайрч, араас нь уулын троллууд нүсэр алхаагаараа газар доргион айсуй.

Их хаалганы дэргэд аюумшигт сүрлэг тулалдаан овозож байна. Тэнд Дол-Амротын баатар вангууд, Минас-Тиритийн шилдгийн шилдэг дайчид алхам ч ухралгүй алалдаж байлаа. Сум, жаднууд үүл мэт бөөн бөөнөөр нисэлдэж, бүслэлтийн цамхгууд нуран унаж, бамбар шиг дүрэлзэн шатна. Их хаалганы хоёр талаар бүслэлтийн цамхаг, харвагчуудын сэг, үхдлүүдийн хүүр зайгүй овоорч байсан ч дайсны шинэ шинэ хүч шавааралдан дайрсаар.

Гронд мөлхөж ирлээ. Тэрний бүрхүүл галд шатдаггүй ажээ. Тэрнийг чирж яваа аварга том араатнууд байн байн хажуу тийш үсэрч, тоо томшгүй олон орхуудыг гишгэлэн, үхдлүүдийг аргаш шидлэвч улангассан олон дайсан дахин бөөгнөрөн дайрсаар байлаа.

Гронд улам ойртов. Бөмбөрүүд галзуурсан мэт нижигнэж, дайснуудын уул мэт овоорсон хүүрнүүд дээгүүр юүдэнг нь буулгасан хар цувтай, асар том хар морьтон аймшгийн хий үзэгдэл мэт гарч ирэв. Тэр аажуухан урагшилж ирэхэд цайзын хамгаалагчдын сум биенээс нь ойж эргэн тойронд нь унаж байв. Тэр бүдэгт гэрэл цацарсан урт илдээ дээш өргөлөө. Дайрч байгаа, хамгаалж байгаа бүгдийг айдас нөмөрч, дайчид зэвсгээ газарт унагаж эхлэв. Хоромхон зуурт нам гүм боллоо.

Дахиад л бөмбөр нижигнэв. Зузаан хайрстай лужир том гарууд Грондыг хаалганд тулгаснаа гэдрэг татаад байдаг хүчээрээ хаалга руу цохив. Хотын дээгүүр аянга ниргэх мэт болов. Гэвч ган баганат ширмэн хаалга цохилтыг дааж үлдлээ.

Тэгтэл Хар жанжин дөрөөн дээрээ босоод үл мэдэгдэх хэлээр хар шидийн хараал аянга ниргэх мэт чанга дуугаар бархирахад тэр муухай дуунд чулуу хүртэл хайлах мэт санагдав.

Тэр гурвантаа бархирч, харвуул гурвантаа нирхийхэд гурав дахь цохилтоор Гондорын цайзын их хаалга уналаа. Ямар нэг далдын их хүч түүнийг хоёр хуваах шиг, аянга хүржигнэн, ширмийн хэлтэрхийнүүд хавь ойроор бутрав.

Хар сүүдрүүдийн жанжин хот руу орлоо. Хар үхэл авчирч яваа түүний араас хар хүрэн туяа цацрав. Тэр дайсны хөл хэзээ ч гишгэж байгаагүй заагийг даван орж ирэхэд Минас-Тиритийн хамгаалагчид байдаг хурдаараа зугтлаа.

Тэрний өмнө ганцхан дайчин л ухарсангүй. Хаалганы цаадах талбай дээр нэгэн морьтон хөдөлгөөнгүй зогсч байгаа нь Аянга морио унасан Гэндальф байв. Дундад газар даяар ганцхан энэ морь л Сауроны үхлийн айдаст автдаггүй учир Рат-Динены хөшөө мэт хэнэг ч үгүй зогсч байв.

- Чамайг оруулах хаалга энд байхгүй – гэж Гэндальф тайван хэлэхэд хар сүүдэр нам зогсов.

Чамд бэлтгэсэн ёроолгүй нүх рүүгээ буц. Гэдэргээ эргэ, тэгээд мөнхийн харанхуй чамайг эзэнтэй чинь хамт залгина. Эндээс тонил!

Хар морьтон юүдэнгээ аргаш буулгахад титэмтэй мөртөө толгойгүй, зөвхөн хүчирхэг хоёр мөрнийх нь хоорондоос улаан гал цоролзож байв. Ам байхгүй мөртөө өшөө хорсол дүүрэн зэвүүн муухай хөхрөв.

- Тэнэг өвгөн минь! – гэж тэр зэвүүн хүйтэн архираад. - Тэнэг өвгөн минь! Одоо миний цаг ирсэн! Үхлээ танихгүй байна уу, чи? Харааланд минь хахаж үх!

Тэр илдээ өндөр өргөхөд илднийх нь ирэн дээгүүр гал цоролзов.

Гэндальф хөдөлсөн ч үгүй. Яг энэ хоромд хотын хаа нэгтээгээс тахиа донгодов. Дайн байлдаан, ид шид... энэ бүхнийг үл тоож, аймшигт алаан хядааны дээгүүр мандаж байгаа өглөөг угтан мэндчилж, чанга бөгөөд цоглог донгодов.

Тэр тахианы дуунд хариу өгөх мэт алсаас эвэр бүрээ цангиналаа. Эвэр бүрээнүүдийн дууг Миндоллуины өндөр хадан уулс цууриатуулан давтав. Умардын том бүрээнүүд улам хүчтэй цууриаллаа. Мустангримчүүд Гондорыг аврахаар амжиж ирэх нь энэ бөлгөө.

Бүлэг 5

Мустанgrimчүүдийн аян дайн

Мерриг нойрноос сэрэхэд хөнжлөөр хучаастай, газарт хэвтэж байлаа. Ийм салхигүй бүгчим байхад моддын навчис яагаад харанхуйд ширжигнээд байгаа юм бол – гэж гайхав. Тэгээд толгойгоо өндийн чагнавал алсын модорхог толгод, уулын бэлээр бөмбөрийн дуу үргэлжлэн нижигнэж байгааг дахин сонсов. Бөмбөрүүд гэнэт чимээгүй болсноо дахин нэг ойртож, нэг холдон нүр нүрхийж байлаа.

Харуулынхан энэ чимээг сонсохгүй байгаа юм болов уу?

Юу ч үзэгдэхгүй харанхуй байсан боловч тэр эргэн тойронд нь морьт дайчид байгаа гэдгийг мэдэж байлаа. Морины хөлс үнэртэж, морьд хөлөө сэлгэн, туурайгаараа боргоцой, навчист өвч хучигдсан газар цавчилна. Дайчид Друаданы ойн дундах Эйленахын нарсан ойд хоноглож байгаа ажээ. Зүүн Анориэны гол зам үүгээр дайрч өнгөрдөг ажээ.

Мерри их ядарсан ч нойр нь сэргэв. Тэд бүтэн дөрөв хоног давхиж байгаа бөгөөд улам өтгөрсөөр байгаа харанхуй сэтгэлийг нь тавгүйтүүлж байв.

Явахгүй байж болох нь байтугай битгий яв, үлд гэж тушаасаар байтал яах гэж тэгж улайран зүтгэснээ өөрөө ч ойлгохгүй байлаа. Өвгөн эзэнтэн түүнийг үгэнд нь оролгүй энд явж байгааг мэдээд хилэгнэхгүй л бол одоо яая гэхэв. Гайгүй биз дээ. Дернхельм эоредын даргач Эльфхельмтай тохиролцсон бололтой. Гэвч даргатай ч, түүний дайчидтай ч Мерри нүүр тулж уулзсан удаагүй, тэдэнтэй ярих гэж оролдоход тэд огт дуугардаггүй байв. Дернхельм ямар ч хэрэггүй илүү ачаа тээж явна гэж тэд дургүйцэж байгаа нь мэдээж. Дернхельм энэ хугацаанд хэнтэй ч үг сольсонгүй. Мерри өөрийгөө ямар ч хэрэггүй өчүүхэн амьтан гэж бодоход дэндүү гунигтай байлаа. Дээрээс нь бас байдал маш түгшүүртэй болов. Дайчид цаашаа явах газаргүй болсон юм шиг санагдаж байв. Тагнуулчдыг илгээхэд зарим нь эргэж ирсэнгүй, зарим нь яаран давхиж ирээд, зам дайсанд эзлэгдсэн байна, Амон-Диний дохионы галтай уулнаас баруун тийш гурван бээр газарт дайсны том бүлэг буудалласан байна, гол замаар гурван бээр орчим газарт дайсны тоолшгүй олон цэрэг цувж явна, замын хоёр талын толгодоор орхууд язганаж байна гэж илтгэв. Конунг, Эомер хоёр шөнийн зөвлөгөөн хийлээ.

Мерри хэн нэгэнтэй ярилцах юмсан гэж байж ядаж байв. Тэр Пинийг санаад бүр ч урам хугарав. Хөөрхий Пин бүслэгдсэн чулуун хотод гав ганцаараа байгаа, аймшиг гэхээс өөр юу гэх билээ. Мерри Эомер шиг өндөр чилгэр баатар ван болоод, бүрээ үлээж, Пинийг аврахаар давхих юмсан гэж мөрөөдөв. Тэр өндийж суугаад дахин бүрэн дууг сонсоход бүр ойрхон нижигнэж байлаа. Төдөлгүй аяархан ярилцах сонсдож, моддын завсраар хагас халхалсан дэнлүүнүүд гялсхийнэ. Дайчид харанхуйд хөдөлж эхэлжээ.

Нэг өндөр хүн түүнд тээглэж бүдрээд “Хараал идсэн нарсны үндэс” гэж хараал тавихад нь Мерри түүнийг дуугаар нь Эльфхельм даргач байна гэж танив.

- Би нарсны үндэс биш ээ, ноён даргач минь, боодолтой ачаа ч биш, ердөө л шалбарсан

хоббит байна. Уучлал гуйх хэрэггүй, харин юу болоод байгааг хэлээд өгөөч - гэж түүнийг хэлэхэд.

- Одоохондоо юу ч болоогүй байна, баярлалаа, хараал идсэн хар гай минь, гэвч эзэн захирагч биднийг бүгд бэлэн бай гэж тушаасан, нэг цагт хөдөлнө.

- Тэгэхлээр дайсан довтолж байгаа байх нь ээ? Энэ тэдний бөмбөрийн дуу юу? Хэн ч сонсохгүй байхыг бодоход би л хий юм сонсоод байна гэж бодсон юм

- Үгүй дээ үгүй, дайснууд ууланд биш, зам дээр байгаа, харин энэ бол ойн зэрлэгүүдийн бөмбөрийн дуу. Тэд нар хоорондоо алсаас ингэж ярилцдаг юм. Тэд нар Друаданы ойд амьдардаг, аль эртнээс л энд амьдарсан шиг байгаа юм, одоо цөөхөн үлдсэн л дээ, тэд яг зэрлэг араатан шиг их зальтай нуугддаг юм. Уул нь тэдэнд Гондор юм уу, Ристаниин дайн огт падгүй боловч одоо энэ харанхуй, орхуудын цуваанаас айж байгаа юм, Харанхуй эрин эргээд ирлээ гэж айж байгаа. Үнэхээр ч тэгж бодмоор байгаа биз дээ. Тэд бидэнд дайсагнаагүй нь их сайн хэрэг, тэдний сум нь хортой, ойд бол тэдэнтэй тулалдана гэж санахын ч хэрэггүй. Тэд Теоденд тусалъя гэсэн санал тавьж байна. Удирдагчийг нь сая эзэн захирагч руу орууллаа. Дэнлүүтэй хүмүүс явж байхыг хараа биз дээ. Би өөр юу ч мэдэхгүй, гүйцээ, хэл ам сугалчих гээд. Би тушаал биелүүлэхээр явлаа. Харин чи ачаа мөн ч бай, биш ч бай одоо ачуул!

Тэгээд тэр харанхуйд орж алга болов.

Меррид зальтай зэрлэгүүд, хортой сум тийм ч их таалагдсангүй. Айсандаа яахаа мэдэхгүй байв. Юу болохыг хүлээж суух тэвчээр хүрсэнгүй, намайг юу хүлээж байгааг мэдсэн нь дээр гэж шийдээд сүүлчийн дэнлүүний араас гэтэв.

Эзэн захирагчийн майхныг аварга том модны доорх ойн чөлөөнд босгожээ. Модны мөчрөөс том дэнлүү өлгөж дээрээс нь бүрхүүл хийжээ, дэнлүүний бүдэг гэрэлд Теоден, Эомер хоёр сууж байх бөгөөд өмнө нь хөгшин хожуул шиг жижигхэн хар хүн завилан суужээ. Түүний махлаг эрүүнээс хатсан хөвд шиг туг сахал унжиж харагдана. Пагдгар, зузаан биетэй, бүдүүн гартай, богинохон хөлтэй тэр эр өвсөн банзлаас өөр хувцасгүй аж. Мерри түүнийг хаа нэгтээ харсан юм шиг санагдаж, гэнэт Дунхергт үзсэн пукколууд санаанд нь оров. Тэнд байсан чулуун хөшөөнүүдийн нэг нь амилчихсан юм уу, эртний урчуудын урласан тэр хүмүүсийн холын төрөл юм уу бүү мэд.

Мерри тэдэнд ойртон гэтэж очиход бүгд чимээгүй сууж байснаа зэрлэгүүдийн ахлагч ярьж эхлэв. Түүнээс нэг юм асуусан, тэр хариултаа бодож суусан бололтой. Дуу хоолой нь баргил, намуухан бөгөөд гайхалтай нь нийтийн хэлээр ярьж байв. Эхэндээ жаахан түгдэрч, жигтэй хачин үгс оруулж байлаа.

- Үгүй дээ, морьтнуудын эцэг минь, бид дайчид биш, бид бол анчид. Бид ойн гөрөөсийг намнаж амьдардаг, горгунууд харагдвал харвадаг, орх-хүмүүст дургүй. Горгунууд танай ч дайсан. Тиймээс бид чамд туслахыг хүссэн юм. Зэрлэг хүмүүс холоос сонсдог, холоос үздэг, бүх зөрөг жимийг мэднэ. Зэрлэг ард түмэн энэ газарт аль эртнээс амьдарч ирсэн, чулуун байшингууд баригдахаас өмнө, усан дотроос өндөр хүмүүс гарч ирэхээс ч өмнө энд амьдарч байсан юм.

- Дайчдын туслалцаа бидэнд хэрэгтэй байна – гэж Эомер хэлээд чи болоод цаад гурваас бидэнд ямар тусламж ирэх юм бэ? –гэхэд.

- Мэдэх тусламж - хэмээн зэрлэгүүдийн толгойлогч хариулж. - Бид хаашаа л харна, бүгдийг үздэг, бид өндөр уулан дээрээс хардаг. Чулуун хотод их хэцүү байгаа. Орох орц, гарах гарцгүй болсон. Эргэн тойронд нь гал түймэр дүрэлзэж байсан. Одоо дотор нь түймэр асч байна. Чи тийшээ явж байгаа биз дээ? Чи хурдан давхих хэрэгтэй. Морины их замаар явж болохгүй, тэнд горгунууд, бас – гээд богино гараараа зүүн зүг рүү заагаад – тэндээс ирсэн харийн хүмүүс байгаа. Олон олон, та нар тийм олон биш гэлээ.

- Тэднийг тийм олон гэж чи яаж мэдэж байгаа юм бэ? - гэж Эомер асуухад зэрлэг хүний хавтгай нүүр, хар нүдэнд ямар ч сэтгэл хөдлөлийн илрэл тодроогүй боловч дуу хоолой нь ууртай, гомдсон шинжтэй сонсдов.

- Зэрлэгүүд бид бол чөлөөт ардууд болохоос биш тэнэг хүүхэд биш. Би бол агуу удирдагч Ган-бури-Ган. Би тэнгэрт байгаа оддыг тоолж чадна, моддын мөчир дээрх навчсыг тоолж чадна, харанхуйд хүмүүсийг тоолж чадна. Танай цэрэг арав дахин, дахиад дөчин арваар тав дахин олон байна. Тэдний цэрэг танайхаас олон. Удаан байлдана, хэн нь хэнийгээ дийлэх вэ? Чулуун хотын эргэн тойронд дахиад зөндөө олон байгаа.

- Хараач гэм! Бүгд үнэн байна шүү - гэж Теоден хэлээд – Замыг хөндлөн ухаж, зангуу хаясан байна гэж манай тагнуулчид мэдээлсэн. Шууд дайраад тэднийг барахгүй.

- Гэлээ ч гэсэн алгуурлаж болохгүй. Мундбург шатаж байна! – гэж Эомер хэлэв.

- Ган-бури-Ганы үгийг сонс! – гэж зэрлэг удирдагч тэдний үгийг таслав. - Тэр бүх замыг мэднэ, та нарыг ухсан нүх ч байхгүй, зангуу ч байхгүй, горгунууд ч яваагүй замаар дагуулж явна. Тэр замаар зөвхөн манай ард түмэн болоод зэрлэг араатнууд л явдаг юм. Чулуун байшингийн хүмүүс эрт цагт, их хүчтэй байхдаа олон зам гаргасан юм. Тэд нар анчин ангийн махаа хувааж байгаа юм шиг уулыг хуваадаг байсан. Тэд нар чулуу иддэг байсан байх гэж манай ардууд ярьдаг юм. Друаданаар Мин-Риммон руу их ачаа явдаг байсан. Аль эртнээс явахаа болиод замаа мартсан. Ганцхан зэрлэг хүмүүс бид л мэдэж байна. Тэр зам уулаар явна, уулын цаана гараад өвсөн доогуур нуугдсан, тэгээд Риммоныг тойрч, Динаг дайран доош бууж морины их замтай нийлнэ. Бид та нарыг тэнд хүргээд өгье, та нар бүх горгунуудыг бүгдийг алаад, муухай харанхуйг хурц гэрэлт төмрөөр солиод өг. Тэгвэл зэрлэг ард түмэн зэрлэг ойдоо амар тайван амьдрах болно.

Эомер эзэн захирагчтай ристани хэлээр ярилцсаны дараа Теоден зэрлэг удирдагчид хандаж.

- За яахав, тойрч явья. Ар талдаа их цэрэг үлдээлээ гээд юу хожих юм бэ? Чулуун хот унах юм бол бид эргэж ирэхгүй. Чулуун хот тэсээд үлдвэл бид ялна, өөрсдийнхнөөсөө тасарсан орхуудад бэрх цаг нь ирнэ. Ган-бури-Ган чамайг бид өгөөмөр шагнана, тэгээд чиний үнэнч нөхөд болцгооно.

- Үхсэн хүн шагнал өгдөггүй, найзлахад ч тохиромжгүй, хэрэв та нарыг харанхуй залгичихгүй бол, дараа нь зэрлэг хүмүүсийг дуртай газартаа тэнэхэд нь битгий саад хийгээрэй, тэднийг

зэрлэг араатан шиг ойгоос битгий хөөгөөрэй. Бүү айцгаа, Ган-бури-Ган та нарыг урхинд оруулахгүй. Тэр морьтнуудын эцэгтэй хамт явна, хэрвээ мэхэлсэн байвал алаарай.

- Тэгэх болно шүү! - гэж Теоден баталлаа.

- Бид их зам дээр хэзээ гарах юм бэ? - гэж Эомер асуугаад – Та нар биднийг дагуулж явах юм бол явган явах болно, зам мэдээж нарийхан биз дээ.

- Зэрлэг хүмүүс хурдан явдаг юм. Чулуу бутлуурын хөндийгөөр – гээд тэр өмнө зүг рүү дохиод – Замын эх, төгсгөл хоёр нь нарийхан, гэвч дөрвөн морь зэрэгцээд явж болно. Бид эндээс Амон-Дина хүртэл үүрээр гараад үдээс өмнө хүрнэ.

- Тэгэхлээр тэргүүн шугамынхан долоон цаг явна, арын шугамынхан арван цаг орчим явна. Замд саад тохиолдохыг хэн байг гэхэв, тэгээд ч жагсаал их сунана. Дараа нь зам дээр гараад шууд бүрэн жагсаал эмхэлж амжихгүй. Одоо хэдэн цаг болж байна? – гэж Эомер асуухад.

- Хэн мэдэхэв, тас харанхуй байна шүү дээ - гэж Теоден хэлэв.

- Харанхуй байж л байна, шөнө өнгөрсөн - гэж Ган хэлээд – Нүд нарыг харахгүй байхад арьс мэдэрдэг юм. Нар Зүүн уулын дээр байна. Тэнгэрийн талбайд гэрэлтэй байна - гэв.

- Тэгвэл хурдхан хөдөлье. Өнөөдөр яагаад ч амжихаас өнгөрсөн, ядаж маргааш хүрье - гэж Эомер хэлэв.

Мерри цааш нь чагнасангүй, чимээгүйхэн гэтэж холдоод замд гарахад бэлдэхээр гүйв. Ингээд маргааш тулалдаан болно, цөөхөн л хүн амьд үлдэх юм шиг байна даа. Гэвч тэр дахин Пиний тухай, Минас-Тирит дэх түймрийн тухай бодоод айдсаа яаж ийгээд дарж байлаа.

Өдөр тайван өнгөрөв. Замд дайсны отолт, толгойн сэргийлэх тааралдсангүй. Дайчдын цувааны хоёр талаар анчин зэрлэгүүд хамгаалж, тэдний завсраар дайсны тагнуул байтугай хулгана ч шургах боломжгүй байв. Бүслэгдсэн хотод ойртох тусам харанхуй улам өтгөрч, хүмүүс болон морьд харанхуй сүүдрийн цуваа мэт санагдана. Цуваа бүрийг газарчин тэргүүлж, өвгөн удирдагч эзэн захирагчтай зэрэгцэн явлаа. Эхлээд удаан урагшилж байв. Чулуу бутлахын хөндий рүү өтгөн бутан шугуй дундуур морио хөтлөн налуу руу буухад амаргүй байв. Орой болохын өмнөхөн тэргүүн ангийн цуваа Амон-Диний зүүн бэл дэх саарал шугуй руу орж, асар том хавцал руу уруудав. Энэ хавцлаар нэгэн цагт Анориэний их замд нийлсэн өргөн зам гаргасан бөгөөд олон зуун жил үүгээр хүмүүс яваагүй, мод бут өөрийнхөөрөө эзэн сууж, зам ургамал, сул асган доогуур алга болжээ. Гэвч энэ шугуй Ристанийн цэргийн сүүлчийн далдлалт болж, тэдний урдаас тэгш тал цэлийн угтаж, зүүн өмнө талд чулуурхаг нуруунууд сүглийлцэж, тэдгээрийг түшин өндийх мэт асар өндөр Миндоллуины хадан уул сүндэрлэнэ.

Эхний цуваа зогсч, арын цуваа Чулуу бутлахын хөндийгөөс гарч ирэхэд саарал шугуйн гүнд буудаллав. Эзэн захирагч жанжингуудыг зөвлөгөөнд дуудлаа. Эомер тагнуулчдыг илгээх гэтэл өвгөн удирдагч Ган толгой сэгсрэн болиулав.

- Морьт дайчдаас тагнуулд илгээх хэрэггүй. Энэ харанхуйд үзэгдэх юм бага, манайхан аль хэдийн бүгдийг харсан. Одоохон хүрч ирээд юу харснаа надад хэлнэ - гэлээ.

Жанжингууд цугларч, дараа нь хаанаас ч гараад ирсэн юм бүү мэд, пукколууд ирцгээв. Бүгдээрээ хөгшин Ганыг хуулбарласан юм шиг адилхан. Тэд ээлж дараалан удирдагчтайгаа гайхалтай хачин хэлээрээ ярилцав. Ган тэдний яриаг сонссоны дараа эзэн захирагчид хандаж.

- Манайхан үзсэн харснаа бүгдийг ярилаа. Ар талд аюултай байна, болгоомжил! гэж байна. Диний цаана, нэг явах газарт маш их цэрэг байна гэнэ – гээд тэр баруун зүг заав. Урд талд юу ч алга, чулуун далан хүртэл хоосон зам л байна гэнэ. Чулуун далангийн тэнд дахиад олон дайсан байна. Горгунууд шинэ чулуун даланг аянгын гал, хар төмөр бороохойгоор хэмхэлж байна гэнэ. Айж болгоомжилсан юм алга, эргэн тойрноо огтхон ч харахгүй байна гэнэ. Бүх замыг бүгдийг нь эзэлсэн гэж бодоцгоож байгаа юм байна л даа! – гээд хөгшин Ган хоолойгоо ход ход дуугаргав. Тэр ингэж инээдэг ажээ.

- Сайхан мэдээ байна! – гэж Эомер хэлээд – Энэ чинь харанхуйд гэрэл цацруулах шиг боллоо. Хар муу үйлтнүүд өөрсдийнхөө хар санаанд сохорчээ. Харанхуйгаар нөмөрлөө ч, хичнээн муухай ч гэсэн энэ нь биднийг нуугдахад тусаллаа.

Одоо чулуун дээр чулуу үлдээхгүйн тулд Гондорын дээрээс аянга буулгаж байна, миний хамгийн их айж байсан даланг эвдээд хаячихлаа. Алсын бэхлэлтийн тэнд биднийг удаан тогтоохгүй. Тэрнийг бид явуут дундаа авна, тэнд л хүрээтэх юмсан!

- Чамд дахиад их баярлалаа, ойн хүн Ган-бури-Ган, сайн мэдээ авчирч, сайхан сэтгэлээр тусалсанд чинь баярлалаа. Ан ав чинь олз ихтэй байх болтугай - гэж Теоден хэлэв.

- Горгунуудыг хядахаа мартав аа! Орхуудыг хядаарай! Ойн ард түмэнд сайхан үг хэрэггүй. Өмхий тэнэг харанхуйг хурц гэрэлт төмрөөрөө хөөж арилга! – гэж Ган хэлэв.

- Тэгэх л гэж бид энэ хязгаарт ирсэн юм. Хэн нь хэнийгээ вэ гэдгийг маргааш үзнэ – гэж эзэн захирагч хэлэв.

Ган-бури-Ган өвдөг сөхрөн суугаад салахын ёс болгож, духаа газарт хүргэв. Тэгснээ босч ирээд ямар нэг юмны үнэр авсан мэт сэртэсхийв. Нүд нь гялалзаж байна.

- Сэвэлзүүр салхи сэнгэнэж байна! – гэж тэр хашгирахад зэрлэг хүмүүс бүгд ухасхийж, нүд ирмэх зуурт харанхуй дунд алга болов. Дахиад зүүн зүгт бөмбөрүүд бөглүүхэн нижигнэсэн ч ристаничууд энэ удаа ойн зэрлэгүүдийн бөмбөрөөс айх шалтгаан байсангүй.

- Цаашаа газарчгүй явцгаана. Тайван цагт манайхан үүгээр явдаг л байсан - гэж Эльфхельм хэлэв. - Жишээ нь би нэг ч биш, хоёр ч биш удаа явж байсан. Одоо зам дээр гарцгаая, зам өмнө зүг рүү эргэнэ, Пеленнорын бэхлэлт хүртэл долоон бээр хүрэхтэй үгүйтэй газар үлдсэн. Замын хоёр тал их өвсөрхөг. Гондорын мэдээчид энэ замаар хар хурдаараа давхиж явсан юм. Бид илүү шуугиан гаргахгүйгээр хурдан явах болно.

- Биднийг хайр найргүй хатуу цавчилдаан хүлээж байгаа, хүчээ сэлбэх хэрэгтэй. Энд амраад шөнөөр хөдөлө. Бэхлэлтэд үүрээр хүрнэ, үүр цайсан ч, цайгаагүй ч эзэн захирагчийн дохиогоор дайсныг цохие, үүр шөнийн зааг хамгийн зохистой цаг – гэж Эомер санал гаргав.

Эзэн захирагч энэ саналыг дэмжиж, зөвлөл тарж, жанжингууд тус тусын анги руугаа явав. Гэвч Эльфхельм удалгүй эргэж ирлээ.

- Бид орчин тойрныг тандлаа. Үнэхээр эргэн тойронд амьд амьтан алга. Харин замын хажуугаас хоёр морьтон алагдсан байхыг оллоо.

- Юу гэнэ ээ? - Тэгээд? – гэж Эомер асуув.

- Алагдсан хүмүүс Гондорын элч нар болох нь илэрхий байна. Нэг нь Хиргон юм шиг байна, гарт нь Хүрэн сум байна, харин толгой нь алга. Өөр нэг юм байна. Тэднийг баруун тийш давхиж явахад нь хөнөөсөн нь илт байна. Тэд бэхлэлтийг дайснууд аль хэдийн эзэлснийг үзээд буцаж давхисан байх. Хоёр хоногийн өмнө болсон байна. Хот хүрээд эргэж амжихгүй байсан.

- Яагаад ч амжихгүй байсан! – гэж Теоден хэлээд - Тэгэхлээр Денэтор бидний талаар юу ч мэдэхгүй, биднийг бараг хүлээгээ ч үгүй байх нь дээ.

- Хожимдсон ч хожигдохгүй, хэзээ ч очихгүй байснаас хожимдоод ч бол очсон нь дээр - гэж Эомер хэлэв. - Магадгүй, эртний энэ үг хэзээ хэзээнийхээс үнэн байж мэднэ шүү.

Гүн шөнөөр ристанийн дайчид Миндоллуины бэлийг ороосон замын далангаар чимээгүй хөдлөв. Тэртээ өмнө, харанхуй тэнгэрийн хаяанд түймрийн хүрэн улаан туяа татаж, агуу их уулсын хясаат хажуу харанхуй дундаас сүглийн бараантана. Пеленнор хүрэхэд тун бага зай үлдээд байх үес үүрийн өмнөх харанхуй дөхөж байлаа. Эзэн захирагч эхний цуваанд бие хамгаалагчид, туслахуудтайгаа, түүний араас зоред Эльфхельмын анги явж байсан бөгөөд Дернхельм харанхуйд бусдадаа ажиглагдамгүй сэмхэнээр цувааны тэргүүн рүү дөхөж байгааг Мерри ажиглав. Тэгсээр Теодены хамгаалагчдын ард хүрээд ирлээ. Морьт дайчдын цуваа зогсч, аяархан ярилцахыг Мерри сонслоо. Тагнуулчид эргэж иржээ. Тэд бүр бараг цайзын дэргэд хүртэл давхиад иржээ.

- Хаа сайгүй гал дүрэлзэж байна эзэн минь, - гэж тэдний нэг нь илтгэж байна. - Хот ч шатаж байна, эргэн тойрны суурингууд ч шатаж байна. Хязгааргүй олон цэрэг байгаа юм шиг байна. Дайсан бараг бүх хүчээ хэрмийн дэргэд аваачжээ. Наана үлдсэн хэсэг нь хаашаа ч харалгүй бэхлэлтүүдийг нурааж байна.

- Тэр зэрлэг хүн юу гэж хэлснийг санаж байна уу, эзэн минь? – гэж өөр нэг дайчин асуугаад. - Намайг Видфара гэдэг, тайван цагт би тал газар амьдардаг байсан, мэдэрхүй их сайтай, салхийг мэдэрч чадна. Салхи өөрчлөгдөж байна. Өмнө зүгээс салхилж байна, бага зэрэг тэнгисийн үнэртэй байна. Нэг үгээр хэлэхэд, үүр цайх гэж байна, биднийг бэхлэлтийн хажуугаар өнгөрөхөд харанхуй сарнина!

- Хэрэв чиний мэдээ үнэн бол Видфара минь, хувь заяа чинь чамайг одоо болоод олон жил

ивээх болтугай! - гэж Теоден хэлэв. Тэр өөрийнхөө хүрээний дайчдад хандаж - Ристаниин морьт дайчид, Эорлын хөвгүүд ээ, эрэгчин эмэгчинээ үзэлцэх цаг ирлээ! Та нарын өмнө галан далай, шороо шиг олон дайсан байна, та нарын орон гэр тэртээ хойно үлдсэн. Та нар бусдын газар нутаг дээр тулалдах хувь тохиосон ч тулалдаанд байгуулсан гавьяа чинь үүрд та нарынх байх болно. Эзэн хаан болоод эх орондоо өргөсөн тангаргаа биелүүлцгээ, эвдэршгүй найрамдлын үүргээ биелүүлцгээ! – гэж чангаар хэлэхэд эхний цувааныхан бүгд сонсов.

Дайчид илдээ бамбайдаа цохилоо.

- Эомер, хүү минь! Чи тэргүүн хороог эзэн захирагчийн хамгаалалт болон хорооны араас авч ор! Эльфхельм баруун талаар бэхлэлтийг тойрч ор! Гримблад чи зүүн талаар нь ор! Бусад хороод байлдааны байрлалын дагуу энэ гурван чиглэлээр араас нь орцгоо! Дайсны бөөгнөрлийг зад цохицгоо! Одоохондоо үүнээс өөр шийд гаргах боломж алга. Бид хотын гадна, дотор юу болж байгааг мэдэхгүй. Урагшаа! Харанхуй сөнөтүгэй! – гэж Теоден захирав.

Дайчид эгнээ эгнээгээрээ ухасхийн давхилаа. Видфара үүр цайна гэж хэлсэн ч одоохондоо тас харанхуй. Мерри Дернхельмын ард сундалдаад зүүн гараараа бүснээс нь барьж, баруун гараараа илдээ тэмтрэн шалгаж явлаа. “Тийм байлдаанд чи юу хийх юм бэ, эрхэм Мериадок минь?” гэж өвгөн Эзэн захирагчийн хэлсэн үг юутай үнэн болохыг ойлгож байв. “Нэг дайчинд тээр болох л гэж зүтгэж дээ, яаж ийгээд морины нуруун дээр тогтож байх юмсан, унавал гишигчээд хаячихна, хэн харах вэ дээ!” – гэж тэр бодож явав.

Дахиад ердөө ганцхан бээр давхих үлдлээ, тэр ганц бээрийг Меррийн бодлоор бол дэндүү хурдан давхиад өнгөрөв. Зэрлэгээр хашгиралдах, зэвсэг харшилдах сонсдоод дахин чимээгүй болов. Хэрмийн дэргэд орхууд тийм ч олон байсангүй, тэднийг юуны ч учир олоогүй байхад нь гэнэт дайран хоромхон зуурт зүйл дуусгав. Раммас-Экорын баруун хаалганы дэргэд эзэн захирагч жолоогоо татлаа. Дернхельмийн хороо баруун талаар дайрч байгаа боловч тэр эзэн захирагчийн ард явлаа. Гимбладын хороо хэрмийн хананд гарсан том нүхний дэргэд зогсов.

Мерри Дернхельмын араас шагайж харав. Тэднээс арваад бээрийн зайтай Минас-Тиритийн хананд түймэр дүрэлзэж, хотыг ойрын суурингуудаас асар урт галан хөшгөөр зааглажээ. Талд тас харанхуй, салхи ч үгүй.

Мустангримын дайчид задарсан далангаар их ус урсан орж байгаа шиг чимээгүй бөгөөд шуурхай урагшлан ойртсоор. Хар жанжин Гондорын бат бэх хэрмийг эргэж харах сөхөөгүй дайрсаар, араас нь ирж байгаа аюулын талаарх түгшүүрт мэдээ аваагүй байлаа.

Эзэн захирагч дайчдаа галт шуудуу болон дайсны цэргийг тойрч, зүүн тийш эргүүлэв. Маш азтай, сэмхэн тойрч чадсан боловч Теоден шийдэж чадахгүй алгуурлаж байлаа. Тэр дахиад зогсов. Одоо хот ойрхноос харагдаж байна. Утаа тортог, хүүрний үнэрт хамар цоргино. Морьд тургилж, чихээ солбилон байж ядна. Гэвч Эзэн захирагч Цагаан дэлтийнхээ нуруун дээр хөдөлгөөнгүй суугаад мөхөж буй Минас-Тирит рүү харж зогсов. Тэр айж балмагдан, насны хүндэд дарагдсан мэт харагдав. Түүний зовлонт айдас, эргэлзээ тээнэгэлзэл Меррид дамжих шиг санагдлаа. Зүрх нь булгилж, цаг хугацаа зогссон юм шиг. Тэд хожимджээ. Хэзээ ч хожимдож байгаагүйгээрээ хожимджээ! Теоден буурал толгойгоо гудайлган, мориныхоо жолоог эргүүлж, цэргээ ууланд нуухаар дагуулж явах гэж байлаа.

Гэнэт ямар нэг өөрчлөлт гарсныг Мерри мэдрэв. Салхи нүүр рүү нь үлээж байна! Үүрийн гэгээ туслаа. Тэртээ өмнө зүгт үүлс сааралтан хуйларч, цаанаас нь үүрийн туяа гийв. Тэгтэл газар дороос аянга дэлбэрэн хотыг дундуур нь хуваагаад хаячих шиг болов. Нүд сохлом хурц гэрэл хоромхон зуурт гялсхийн хар-цагаан өнгөт хэрмийг гийгүүлж, тэртээ өндөрт цамхгийн мөнгөлөг орой гялсхийв. Дараа нь харанхуй битүүрч, хөнөөлт хүнд нүргээнд газар доргив.

Гэвч эзэн захирагч тэр чимээг сонсонгуут гэнэт нуруугаа эгцлэн өндөр чилгэр дайчин болж хувирлаа. Тэр дөрөөн дээрээ босоод ер бусын тод тунгалаг, чанга дуугаар..

Теодены морьт дайчид зэвсгээ тулалдаанд!

Улайрсан гал, уулгалсан тулалдаанд урагшаа!

Жад байлдаанд, бамбай хамгаалалтад!

Илдний ирээр өдрийн гэгээг авчирая!

Гондорын төлөө үхэх сэхэхээ үзэх тулалдаанд! – гэж захирав.

Дараа нь тэр тугч Гутлафаас том эвэр бүрээ авч, хүнгэнэтэл үлээтэл түүний үлээлтийн хүчийг даалгүй бүрээ хоёр хэсэг зад үсрэв. Ристанийн дайчдын бүх хороод хариу бүрээдэхэд уул талаар дүүрэн аянга мэт цууриаллаа.

Гондорын төлөө үхэх сэхэхээ үзэх тулалдаанд!!

Теоден Цагаан дэлт рүү тонгойж нэг юм хашгиран хэлэхэд Цагаан дэлт үсрэн дүүлж, ногоон тал дээгүүр салхи татуулан хурдалж яваа Цагаан морьтныг гүйцэн нисэх мэт одов. Дайчид араас нь ялимгүй хоцорсхийн нисэх мэт хурдаллаа. Араас нь Эомер дуулган дээрх цагаан морины сүүлээ дэрвүүлэн ухасхийв. Түүний эоред морь хөөс цахруулсан хүрхрээ мэт уулгалан хурдлавч Цагаан дэлт хол тасарчээ. Теодены царай нэн сүрлэг жавхаатай гялалзаж, эртний дайчин өвөг дээдсийнх нь онгод орсон байлаа.

Алтан дуулга нь нар шиг гялалзан туяарч, аргамаг хөлгийнх нь дөрвөн туурайн дорх өвс хурц ногоон дөлөөр цацарч байв. Өглөө болж, Тэнгисээс үлээх салхи гүн харанхуйг хөөн, Мордорын бөөн хар хүч айдаст авган яах ч учраа олохоо байж, орхууд тал тийшээ зугтавч илд жад, эрмэг морьдын туураинд амиа тавьж байлаа. Ристаниин дайчид нэгэн хоолойгоор дайчин дуугаа аялан, тулааны онгодын хүчин дор дайснуудыг өвс хяргах мэт ханаруулан хядаж, тэдний сүрлэг бөгөөд сайхан дуу бүслэгдэгсдийн урам зоригийг ундруулж байлаа.

Бүлэг 6

Пеленнорын тал дахь тулалдаан

Гэвч Гондорыг газрын хөрснөөс арчих даалгаврыг орхуудын толдгойлогчид ч, дээрэмчдийн атаманд ч өгөөгүй байлаа. Харанхуй Хар эзний товлосон хугацаанаас өмнө замхарч, энэ удаа хувь заяа түүнийг хуурч, ертөнц түүний эрх мэдлээс мултарчээ. Ялалтын санаачилга түүний гараас гулсан унав. Гэвч түүний гар хүчирхэг хэвээр, бүслэлтийн удирдагч ван, бөгжтөн, сүг сүүдрүүдийн жанжин урьдын адил аймшигтай, хүчтэй хэвээрээ. Эрх мэдэл нь хэмжээлшгүй хэвээрээ байлаа. Тэр хаалганаас зайлж, алга болов.

Ристаниин эзэн захирагч Теоден Мөрөн, Их хаалганы хоорондох зам дээр гарч ирээд нэг бээрийн цаана байгаа хот руу эргэж харав. Тэр үлдсэн дайснуудыг харахаар морины жолоо татахад дайчид нь хүрээлэн зогсов. Тэдний дунд Дернхельм байлаа. Баруун талд, хэрмийн ханын ойролцоо Эльфхельмийн дайчид бүслэлтийн машинуулыг хэмхчиж, орхуудыг цавчиж, жадлан галт шуудуу руу хөөн оруулж байна. Пеленнорын хойт хагасыг бараг бүрэн эзэлж, дайсны майхнуудыг шатаан, орхууд анчнаас зугтаасан араатан мэт мөрөн рүү харайлдаж, ристаничууд тэднийг баруун солгойгүй цавчилж байв. Гэвч бүслэлтийн хэсэгт дайсан тоо томшгүй олноороо харанхуйлж, хаалгыг урьдын адил хаасаар, тэнд дайснууд өмнө зүгээс үй олноороо нэмэгдэн ирсээр байлаа.

Хородримчүүд замыг эзэлж, тэдний морьт цэргүүд эзнийхээ тугийг хийсгэн давхилдана. Дайсны жанжин үүрийн гэгээнд Ристанийн эзэн захирагч багахан хороо цэрэгтэйгээ гол хүчнээсээ хол тасарсныг харж байв. Хар жанжин галзууртлаа уурлаж, байлдааны уриа хашгирахад хар могойтой улаан туг хийсгэсэн үй олон морьт цэрэг илдээ сугалан довтоллоо.

Гэвч Теоден барьц алдаж сандарсангүй. Цагаан дэлтэд нэг үг хэлэхэд мустангримчүүд дайсны давалгаа мэт их хүчний өөдөөс дайрав. Морины хар хурдаар хоёр талаас халз уулзахад умардынхан цөөн хүнтэй ч гэсэн цөс нь ялалтаар буцлан хөөрч, дайсны урт урт жадыг алдалгүй тас цавчиж байлаа. Тэд яг ойн түймэр мэтээр язганасан олон дайсны бөөн дундуур зүсэн ороход Тингелийн хүү Теоден өмнөдийн жанжныг жадаар нэвт сүлбэж, илдээрээ тугны ишийг тас хяргаж, тугчийг нь эмээлд нь хүртэл тас цавчив. Хар могойт улаан туг газарт унахад үлдсэн хородримчүүд эргэж харалгүй зугтаав.

Гэтэл юу болох нь энэ вэ! Эзэн захирагч ялалтандаа бахархан зогсч байтал түүний алтан дуулга бүүдгэрч, өглөөний тэнгэр гэнэт харанхуйлж, морьд янцгаалдан ийш тийш давхилдаж, эздээ булгин унагааж эхэллээ. Мориноос унасан дайчид газарт наалдан нам хэвтэж байв.

- Наашаа! Над руу! Харанхуйгаас бүү айцгаа, зорлингийн хөвгүүд ээ! – хэмээн Теоден хашгирлаа.

Гэвч цагаан дэлт айсандаа урд хоёр хөлөө өндөрт өргөн цоройгоод, хар жаданд сүлбүүлэн цангаар янцгаагаад хажуу тийш уналаа. Унахдаа эзнээ дарж унажээ.

Хүнд хар үүл мэт сүүдэр дээрээс нөмрөв. Тэр бол аварга том далавчтай юм байв. Шувуу

гэхэд шувуу биш, дэндүү том, нүцгэн, махир урт хумстай өднүүд бүхий аймшигтай нүсэр далавчтай юм байв. Түүнээс илжирхий өмхий үнэр ханх тавьж байлаа. Тэр бол аль дивангарт сөнөж үгүй болсон ертөнцийн үлдэгдэл, түүний элэнц хуланц аль эрт саран доорх ертөнцийн хаа нэгтээх нүцгэн уулын орой дээр үүрээ зассан бөгөөд шинэ эриний хар муу үйлтнүүд тэднийг ашиглах болжээ. Хар эзэн тэрнийг хайж олоод илжирсэн хүүрээр харамгүй тэжээж, ямар ч шувуутай зүйрлэшгүй том болгоод зарц нартаа өгчээ. Тэр улам улам доошилсоор аль хэдийнэ амьсгал хураасан Цагаан дэлтийн дээрээс бугаад хумст далавчаа эвхэн, хахирган сөөнгө дуугаар гуагалаад, хумсаа шигтгэн зоож, урт нүцгэн хүзүү гаргаж ирэв.

Тэр муухай амьтныг унаж ирсэн эзэн нь хүчирхэг бөгөөд аймшигтай. Хар нөмрөг, ган титэмтэй, хоёр мөрний хоорондох хоосон зайнаас үхдэл сүгнүүдийн жанжны хоосон харц үхмэл гэрэл цацруулж байв. Харанхуй сарнихаас өмнө тэр далавчит мангасаа дуудан ирүүлж, түүнийгээ унан байлдааны талбарт эргэж ирээд цөхрөлөөс найдвэр, үхлээс ялалт олохыг зорьсон ажээ. Тэр урт хар зүү далайлаа.

Гэвч Теоденыг бүгд орхиогүй ажээ. Эргэн тойронд нь алагдсан баатар вантангууд хэвтэж, амьд үлдсэн нь айсан морьдынхоо амыг дийлэлгүй алсад давхин оджээ. Гэвч нэг дайчин үлдсэн нь орь залуу Дернхельм байв. Түүний үнэнч сэтгэл айдсыг дийлэн эзнээ орхилгүй үлджээ. Тэр эцэг шигээ хайрладаг эзэн захирагчдаа гашуудан уйлж байв. Мерри тулалдааны үед мориноос уналгүй үлдсэн боловч хар сүүдэр нисэн ирэхэд Шуурган айсандаа хоёр эзнээ булгиж орхиод тал дундуур давхин одсон байв. Мерри айдастаа амьсгаа нь боогдох шахаж, араатан шиг дөрвөн хөллөн мөлхөж байв.

“Эзэн захирагчийн зэвсэгч бил үү, чи! Эзэн захирагчийн зэвсэгч бил үү, чи! – Тэгвэл чи түүнийг хамгаалах ёстой. Одоо чи миний эцгийн оронд эцэг боллоо гэж чи өөрөө хэлж байснаа санаж байна уу?” – хэмээн тэр үглэнэ. Гэвч түүний бие өөрт нь үл захирагдан дэмий л чичирнэ. Тэр толгойгоо ч өндийлгөж чадахгүй, нүдээ ч нээж чадахгүй байв. Гэтэл гэнэт ёроолгүй харанхуй дундаас Дернхельмийн дуу хоолойг сонсов. Тэрний дуу өөрийнх нь биш юм шиг хачин сонсогдсон ч яах аргагүй танил дуу хоолой нь мөн байлаа.

- Тонил эндээс, илжирхий хүүр минь! Нас барагсдыг тайван орхи!

Тэгтэл өөр нэг зүрх зүсэм хөлдүү дуу хариулав.

- Сүг сүүдэртэй олзных нь талаар бүү марга! Тэгэхгүй бол өөрийнхөө үхлийг үзэхгүй шүү чи. Тэр чамайг булшны ёроол, мөнхийн харанхуйдаа авч одно, тэнд чиний махбодыг зовлон тарчлааж, сэтгэл зүрхийг чинь Үл анигч нүдний харц мөнхөд тарчлаах болно!

Илд хуйнаасаа сугарах чимээ ханхийв.

- Юу дуртайгаараа заналхийл. Би тэртэй тэргүй чамтай тулалдана

- Чи надтай тулалдах юм уу? Тэнэг амьтан! Нэг ч үхэлт эр надад аймшигтай биш.

Тэгэхэд Мерри огт санаанд ороогүй юмаа сонсов. Дернхельм тачигнатал инээхэд түүний цэвэр тунгалаг дуу хоолой нимгэн ган мэт жингэнэв.

- Би үхэлт эр биш! Чиний өмнө эмэгтэй хүн байна. Би Эомундын охин Эовин байна, би чамтай Эзэн захирагч болоод элгэн саднаараа мөрийцье. Хэрэв чи үхэлт амьтан биш юм бол болгоомжлоорой! Хэрэв чи муу хар үхдэл түүнд гар хүрэх юм бол би чамайг тас цавчина шүү.

Далавчит үхээр ууртай шуухитнаад түүн рүү муухай хашгирахад Бөгж эзэгнэгч гэнэт өөртөө итгэл алдарсан мэт дуугүй болов. Мерри гэнэт айдсын хүлээснээс мултарсандаа маш их гайхаж байв. Тэр нүдээ нээж харвал түүнээс арваад алхмын цаана далавчит хар мангас, түүний нуруун дээр үхдэл сүгнүүдийн толгойлогч аймшигт сүүдэр байхыг харав. Зүүн талд, Мерригээс нэлээд зайтай, түүний Дернхельм гэж нэрлэж байсан хүн зогсч байна. Тэр одоо дуулгагүй, олон сүлжсэн алтан шаргал үс нь мөрөн дээгүүр нь намиран буужээ. Түүний харц ширүүн бөгөөд нэвт шувт харж байсан боловч хацар дээгүүр нь нулимс бөмбөрч байв.

Гартаа илд барьж, үхээрийн харцнаас бамбайгаараа халхалжээ.

Тиймээ, энэ бол Эовин мөн, энэ бол Дернхельм мөн байлаа. Мерри Дунхергээс мордохын өмнө анх харсан орь залуу дайчны царайг санав. Тэр царайд итгэлийн гал байгаагүй, үхлийн сүүдэр харагдаж байсан билээ. Мерри түүний хайрлаж харамсахын зэрэгцээ түүгээр бахархаж байлаа. Тэгмэгц түүний дотор хоббитын зөрүүд зориг сэрэв. Тэр нударгаа зангидлаа. Ийми гоо сайхан, ийм эрэлхэг зоригтой Эовин үхэж болохгүй! Хэрэв тэр энд үхэх тавилантай юм бол...

Дайсан Мерри рүү хараагүй боловч тэр аймшигтай харцнаас нь айгаад газарт шигдчихгүйн тулд хөдлөх ч үгүй ажиглаж байв. Тэгээд маш удаанаар мөлхөж эхэллээ. Гэвч Хар толгойлогчийн хувьд Мерри ердөө л шаварт хутгалдсан өт төдий өчүүхэн юм байсан бөгөөд Хар толгойлогч эрэлхэг эмэгтэй баатартай үзэлцэх нь хамгаас чухал байв.

Хар мангас гэнэт далавчаа дэлгэж, хамар сэтрэм өмхий үнэр цацав. Тэгээд агаарт хөөрч, аймшигтай бархиран шүдэрхэг махир урт хушуу, хумснуудаа арзайлгасаар Эовин руу шумбан дайрлаа.

Гэвч Эовин нэг ч алхам ухарсангүй, Ристанийн эзэн хаадын удам эмэгтэй дайчин мөнгөн зүү шиг уян налархай, сүрлэг гоо сайхнаараа гайхуулах мэт зогсоно. Хурц илд агаарт сүнхийн исгэрч, хар мангасын хүзүүг ганц цавчилтаар тас татаж, мангасын толгой газарт чулуу шиг унан өнхрөв. Эовин гэдрэг үсрэн зайлахад толгойгүй мангас өмнөхөн нь унаж, амь тавин тийчилсээр аймшгийн том далавч нь дэлгэгдэн нам болов. Харанхуй шингэрэн сарниж, алтан үст хатан хааныг нарны туяа гийгүүллээ.

Хар морьт толгойлогч босч ирээд, хатан хааны бамбайд урт хар тэвнээ зооход бамбай бут үсэрч, хугарсан гар унжин, Эовины өвдөг нугарлаа. Хар дайсан түүний дээрээс харанхуй үүл мэт нөмрөн авч, нүд нь гялсхийгээд, үхлийн цохилт хийхээр хар тэвнээ далайлаа.

Гэвч гэнэтхэн ганхасхийж, өвдсөндөө чих дөжрөм чанга орилов. Дайсны цохилт Эовныг оносонгүй, тэвнэ нь газарт шигдэв. Түүний араас дайрсан хоббитын илд хар цувьг нь нэвглэн хуягнаас нь доохнуур, өвдөгнийх нь шөрмөсийг тасалсан байжээ.

- Эовин! Эовин! - хэмээн Мерри орь дуу тавин хашгирав. Эовин сүүлчийн хүчээ шавхан өндийгөөд илдээ далайж, дээрээс нь бөхийсөн хүчирхэг мөрөн дээрээс титмийг нь тасар цавчив. Илд шилээр хийсэн юм шиг бут үсэрлээ. Титэм ханхийж дуугараад газарт өнхрөв. Эовин газарт тэрийн унасан дайсны дээрээс тонгойв... Гэвч дайсны цув хөө хуяг нь хов хоосон байв. Газар дээр зөвхөн хэсэг төмрийн хог л үлдэж, амь тавьсан аймшигтай чарлаан үргэлжлэн ульснаа аажмаар салхинд хийсэн алга болов. Газар дээр тэр дуу дахиж гараагүй билээ.

Хоббит Мериадок үхэгсдийн дунд зогсоод нарны гэрэлд ууль шувуу мэт гялбан байв. Хоёр нүдийг нь нулимс бүрхэж, газарт тэрийн хэвтэж байгаа Эовины алтлаг гэрэл цацарсан үс, дараа нь ялалтынхаа эцсийн мөчид үхэж буй Эзэн захирагчийнхаа нүүр рүү харав. Цагаан дэлт айсандаа эзнээ санамсаргүй даран унасны дараа амьсгаа хураах эцсийн мөчдөө эзнээ дороосоо арайхийн гаргажээ.

Мерри бөхийж эзнийхээ гарт уруулаа хүргэв. Теоден харц нь тунгалаг хэвээр байгаа нүдээ нээж, ихэд хүчлэн байж тов тод хэлэв.

- Баяртай ноён хоббит! Өвөг дээдэстээ очих ээлж минь болов. Тэдний дурсгалыг гутаагаагүй гэдэгтээ итгэлтэй байна. Хар могойг би өөрийн гараар үгүй хийлээ. Өглөө бүрхэг байсан, өдөр цэлмэг болно, оройн нар алтарч жаргана!

Меррид хэлэх үг олдсонгүй, дахиад л уйлав.

- Өршөө эзэн минь, өршөө намайг, би чиний зарлигийг зөрчсөн, бидний мөнхийн хагацлыг л уйлж ёслохоос өөр чадах юм алга.

Өвгөн эзэн инээмсэглэв.

- Бүү гунигла. Үнэнч зүтгэлийг буруутгадаггүй юм. Амьдар, баярлаж жарга, гэртээ хариад галын захад тамхилж суухдаа намайг дурсаарай. Би чамд амласнаараа Медусельдэд бид найрлаж чадахгүй нь, чи ч надад өвс ногооны эрдмээ зааж чадахгүй нь... – гээд тэр дуугүй болж нүдээ анив. Мерри түүн рүү тонгойж амьсгаа түгжин чагнавал.

Эомер хаа байна аа? Нүд минь харанхуйлж байна, түүнтэй амьсгал хураахаасаа өмнө уулзах ёстой. Тэр эзэн захирагч болно. Эовинд миний эцсийн мэндийг ч хүргэх учиртай. Тэр минь... надаас хагацах дургүй байсан юм. Хөөрхий минь, охиноос ч минь энхрий байсан юмсан.

- Эзэнтээн, эзэн минь - хэмээн Мерри түгдэрч. - тэр... Түүнийг ... – хэмээн ярих гэж ээрч байх хооронд хүмүүс хашгиралдан, морин төвөргөөн тачигнаж, эргэн тойронд эвэр бүрээ хангинав. Мерри эргэж харлаа. Тэр одоохон дахиад шинэ тулалдаан оволзох гэж байгаа дайны талбарын тэг дунд зогсч байлаа. Тэр тулалдааны тухай бодохоо ч мартжээ. Эзэн захирагч олон цагийн өмнө ялалт, үхэл хоёр руугаа тэмүүлэн давхиж байсан юм шиг санагдавч энэ бол дөнгөж саяхан болсон үйл явдлууд байв.

Мөрний тэндээс дайсны шинэ ангиуд зам дээр гарч, хэрмийн тэндээс моргуулийн арми яаран

наашилж, өмнө зүгээс хорондримчүүдийн морьтой ба явган ангиуд, араас нь байлдааны цамхаг үүрсэн аварга том мумакууд цувж байв. Умар зүгээс дуулган дээр цагаан морины сүүл сугсруулсан Эомерын удирдсан дайчид ирж явна. Тарж бутарсан Ристанийн дайчдыг цуглуулан шинэ хороодыг эмхэлжээ. Гондорын дайчид нэг ч хүн үлдэлгүй хотоос гаран наашилж байна. Тэдний түрүүнд Дол-Амротын мөнгөн хунтай туг намирч харагдана. Түүнийг хараад хэрмийн хаалганы дэргэд байсан дайснууд бутран зугтаав.

“Гэндалф хаана байгаа юм бол? – гэсэн бодол Меррийн толгойд гялсхийв. – Тэр энд байхгүй юм болов уу? Байсан бол Эовин, эзэн захирагч хоёрыг аварч чадаагүй юм байх даа?”

Тэгтэл түүн рүү Эомер болон эзэн захирагчийн туслахууд, амьд үлдэж, морьдоо олж авсан бусад дайчид давхилдан ирэв. Тэд үхсэн мангас руу гайхан харах бөгөөд морьд нь хамраа тачигнуулан үргэж байлаа. Эомер мориноосоо үсрэн бууж, Теоден дээр очоод уй гашуудаа автан хөдөлгөөнгүй зогсов.

Баатар вангуудын нэг нь тугч Гутлафын тас атгсан гарыг арайхийн тэнийлгэж, тугийг салган өргөв. Теоден удаанаар нүдээ нээж, тугаа хараад түүнийг Эомерт өг гэж дохив.

- Ристанийн эзэн хаан танд баяр хүргэе! Явж тулалд, ялж харь! Миний өмнөөс Эовинд мэнд хүргээрэй!

Тэгээд тэр Эовин дэргэд нь хэвтэж байгааг мэдэлгүй халилаа.

Дайчид орь дуу тавин.

- Эзэн захирагч Теоден! Эзэн захирагч Теоден! – гэж хашгирцгаалаа.

Эомер тэдэнд хандаж.

Уй гашууд бүү автацгаа!

Урагш давшин байлдацгаа!

Баатар дайчин агуу тулаанд

Баатрын ёсоор тэнгэрт халилаа.

Цогцсыг нь газарт бунхлах цагт

Цурхиран гашуудах зав олдоно.

Илдний ирэнд амь өрсөх

Их тулаан биднийг дуудаж байна! – гэж эр хонгор дуугаар уриалах мөртөө өөрөө учир зүтгүй эхэр татан уйлж байв.

Тэгээд.

- Хамгаалагчид эндээ үлдээд, цогцсыг нь хүндэтгэлтэйгээр хотод хүргэ. Бусад дайчдын цогцсыг ч гэсэн хотод хүргэ- гэж тушаалаа.

Тэр тулааны талбарт босохгүй үлдсэн дайчдыг тойруулан харж, хэн хэн байна хэмээн тогтоож байтал тэдний дунд төрсөн ганц эгч Эовин нь хэвтэж байхыг харангуут танив. Эомер зүрхийг нь сум нэвт сүвлэн гарах мэт татвасхийж, царай нь хувхай цайн, уур хилэн, уй гашууд дийлдэн үг ч дуугарах тэнхэлгүй болж, харах нүдний өмнө хамаг ертөнц харанхуйлав.

- Эовин, Эовин! – хэмээн эцэст нь орилж - Эовин, чи яаж энд ирээ вэ? Энэ чинь юу болж байгаа юм бэ? Ид шид нь юм уу, солиорол юм уу? Үхэл, үхэл, үхэл! Үхэл биднийг гүйцлээ!

Тэгээд гондорчуудын ирэхийг хүлээлгүй мориндоо үсрэн мордож, дайралтын дохио бүрээдэж, дайчдаа дагуулан дайсны өөдөөс уулгалан довтлов. Тал дээгүүр түүний уриа.

- Үхэл! Үхэл рүү урагшаа! Хайр найргүй хядъя! – хэмээн цууриалав.

Дайчид түүний араас уулгалан довтлов. Мустангримчүүд түрүүчийнх шигээ дуулсангүй, “Үхэл!” – хэмээн нэгэн дуугаар нүргэлүүлж, морьт дайчдын аюумшигт үер Эзэн захирагчийнхаа амьгүй биеийн дэргэдүүр нижигнэн өнгөрвэй.

Хоббит Мериадок нөгөөх газраа нус нулимсандаа хахаж цацан зогссон чигээрээ, хэн ч түүнтэй ярьсангүй, тэр ч байтугай харсан ч үгүй. Тэр нулимсаа арчаад, Эовины бэлэглэсэн ногоон бамбайгаа авч, нуруундаа үүрэв. Тэгээд илдээ хайлаа. Тэр хар жанжины хөл рүү цавчихад гар нь мэдээгүй болсон ба одоо ташуур мэт унжиж байв. Өө, илд нь энэ байна... Гэвч юу болох нь энэ вэ? Илдний ир гал руу хийсэн мөчир шиг уугиж байна, тэгээд нарийхан зурвас татуулан урсч алга болохыг Мерри харав.

Эртний өрнө дахинд давтсан булштаны илдний төгсгөл ийм болов. Дивангарын эринд тэр илдийг давтсан Умардын их эзэнт улсын зэвсгийн дархан үүнийг харсан бол магнай хагартал баярлах байсан биз. Учир нь тэр цагт дунаданчуудад Ангмарын хаан байсан, сүүлд нь сүг сүүдрүүдийн жанжин болсон тэр хар шидтэнээс өөр аймшигтай дайсан байгаагүй билээ. Өөр ямар ч илд, ямар ч хүчирхэг баатрын гарт байлаа гэсэн хар жанжинд өчүүхэн ч хор хүргэхгүй байсан, харин энэ илд түүний үз үзэгдэх махбодыг сүлбэж, хүнд шархдуулан хар шидийн хараалыг үгүй болгосон байлаа.

Жаднуудын ишийг холбон хэдэн цув дэвсээд, дээр нь Теоденийг тавилаа. Тэгээд Эовиныг энхрийлэн өргөж ирээд зэрэгцүүлэн тавьж хот руу авч явав. Бусад дайчдын цогцсыг байлдааны талбарт орхихоос өөр аргагүй байсан тул дайснуудын хүүрээс холдуулж, аятайхан газарт аваачаад, жаднуудаар тойруулан хайс босгов. Тэдний дунд долоон баатар ван, тэргүүн хамгаалагч Деорвин байлаа. Хамгаалагчид эргэж ирээд, дайснуудын хүүрийг галдан шатааж, Цагаан дэлтийн булшин дээр овоо босгоод дээр нь гондор, ристан хэлээр.

Цагаан дэлт хөлөг эзэндээ үнэнч зүтгэлээ.

Цагаа ирэхэд түүнтэй хамт одлоо.

гэсэн бичээс үлдээв.

Тэр булш хожим нь өтгөн өвс, алаг цэцэгсээр хучигдсан өндөр довцог болж, хар мангасыг шатаасан газар тэр чигээрээ харлан үлджээ.

Мерри дамнуурга өргөсөн хамгаалагчдын араас толгой унжуулан сажлав. Дайн тулаан түүнд огт хамаагүй болжээ. Маш их ядарч, гар нь янгинан, бүх бие нь салганан чичирч байв. Тэнгисийн зүгээс борооны үйл хуйлран ирж, гал утаанд бүрхэгдсэн хотын дээрээс саарал нулимсаа асгарууланхан, дээд тэнгэр Эовин, Теоден хоёрын гашуудлыг тайлж байх шиг ээ. Гондорын морьт дайчид тэдэн рүү ирж явааг Мерри нулимст нүдээрээ харав.

Дол-Амротын хаан Имраиль урд нь ирж, жолоогоо татан, агсам мориныхоо чилгэр дөрвөн хөлийг газарт зоох мэт зогсоож.

- Та нар ямар ачаа тээж явна вэ, ристанчууд аа? – гэж асуулаа.

- Эзэн захирагч Теоденыг тээж явна аа бид. Тэр тулаанд амь эрсэдлээ. Манай дайчдыг эзэн захирагч Эомер удирдаж байгаа, дуулган дээрх цагаан морины сүүлээр нь таниарай.

Имраиль мориноосоо үсрэн бууж, Гондорыг амьсгал тасрахын даваан дээр нь аварсан агуу гавьяаг нь хүндэтгэн Теоденийн өвдөг дор гүнээ мэхийн ёслов.

Тэр Эовиныг харангуутаа мэл гайхаж.

- Энэ чинь эмэгтэй хүн байна шүү дээ. Ристаниин хаан, хатан хоёр энд мөр зэрэгцэн тулалдсан гэж үү?

- Үгүй ээ! Энэ бол Эомерын эгч, хатан хаан Эовин, бид түүнийг энд явааг мэдээгүй минь даанч харамсалтай.

Имраиль хаан амьгүй болсон Эовины гоо сайханд биширч, түүний дээрээс бөхийн гараас нь атгаад.

- Ристанчууд аа! – гэж бахардан хашгирав. - Та нарт эмч байхгүй гэж үү? Тэр шархадсан юм шиг байна, үхлийн шарх ч байж мэднэ, гэхдээ надад амьд юм шиг санагдаад байна - гэлээ.

Тэр энгэрийн толио түүний уруулд хүргэхэд болор мэт гялалзсан ган толь үл мэдэг цантав.

- Түргэлээрэй! – гэж тэр хэлээд хот руу элч давхиуллаа. Тэгээд өөрөө дахин өвдөг сөгдөн ёслоод тулааны талбар руу шуургалан давхиж одов.

Пеленнорын талд улангассан галзуу тулалдаан өрнөж, тулааны сүрлэг нижигнээн тэртээ алсад сонсогдож байлаа. Хүмүүсийн галзуу хашгираан, морьдын янцгаалт, бүрээний цууриа, улайрсан мумакуудын бархираан нийлж нэгэн хэмийн аймшигт аялгуу болов. Хотын өмнөд хэрмийн гадна Гондорын явган дайчид шинээр ирсэн моргулийн хороодтой алалцаж байлаа. Морьт дайчид бүгд өмнө зүг рүү Эомерийн дайчдад туслахаар давхижээ. Тийшээ Минас-Тиритийн түлхүүр хадгалагч бөгөөд Лоссарнахын ван өндөр Турин, Ногоолин толгодын

Гирлуин ван, Имраиль хаан вангуудтайгаа явжээ.

Эомерт тусламж юу юунаас чухал байлаа. Тэр уй гашуугаасаа болоод дайсны асар давуу хүч рүү ухаан жолоогүй, ум хумгүй дайран орсон билээ. Ристанийн дайчид дайсны бөөн хүч рүү шуурганд туугдсан түймэр мэт дайран орж, морьт цэргийн эгнээг нь задлан тарааж, явган цэргийг нь хиар цохив. Гэвч дайчдын морьд мумакуудаас айгаад ойртохгүй байсан тул тэдгээр аварга араатангууд юу ч болоогүй юм шиг шивээлэн зогсч, хородримүүд хүчээ дахин эмхлээд бүсэлж эхлэв. Өмнөдийнхний хүч ристанийхаас гурав дахин их байсан ба Осгилиатаас шинэ хүч нэмэгдэн ирсээр байв. Тэд бол дайн ялалтаар дуусмагц Хар эзнийг ирэхээр эзлэгдсэн Минас-Тиритийг хуу дээрэмдэж, Гондорыг үнс нурам болгохоор хүлээж байсан залхаан цээрлүүлэх арми байжээ. Хар жанжинг нь зүйл дуусгасан тул Моргулын захирагч Госмог дайсны цэргүүдийг байлдаанд хөөн оруулжээ. Дайсны армийн дотор том том саран сүх барьсан битүү сахалт үлэмж биетнүүд, Кхандын зэрлэг дээрэмчид, улаан хүрэн цувтай хүдэр хар биетнүүд, цагаан нүдтэй, урт улаан хэл унжуулсан өмнөдийн хар троллууд гээд долоон жорын юмнууд байв. Тэдний нэг хэсэг нь ристаничуудын араас ороож, зарим хэсэг нь тусламж ирэх замыг хаахын тулд баруун тийш газрын хөрс хуулрах мэт ханаран урсч байлаа.

Тэгтэл аз завшаан Гондор болон түүний холбоотнуудаас урваж, итгэл найдвар дахин бүүдгэрч, хотын хэрэм дээрээс хирдхийн хашгиралдах сонсдов. Үд дунд болж, борооны үүл умар зүг рүү нүүн одож, жихүүн салхи үе үе үлээн, хана тодоор гийж байсан цаг билээ. Хэрмийн харуулууд алсаас аймшигтай үзэгдэл наашилж байгааг харжээ.

Харлондын тохойгоос цааш Андуин чигээрээ өргөсөн шулуун урсдаг бөгөөд тэнд үй олон хөлөг онгоц мөрний мандлыг хар ялаа мэт бүрхэн наашилж байгаа нь хэдэн бээрийн газраас харуулуудад харагджээ. Энэ удаа хотын хамгаалагчид айж сандран, үймж шуугилдахаас өөр юу ч хийх сөхөөгүй болов. Том том хар далбаат онгоцууд араасаа салхинд хөөгдсөөр нэн хурдан ойртож байлаа.

- Умбарын далайн дээрэмчид байна! – хэмээн хүмүүс хашгиралдаж. - Умбарын дээрэмчид! Хараач! Умбарын дээрэмчид хөвөөд ирлээ! Тэгэхлээр, Бельфалас дайсанд эзлэгдсэн байна, мөрний хөвөө, Лебеннин ч дайсны гарт оржээ. Далайн дээрэмчдийн флот наашаа ирж байна! Энэ бол хувь заяаны шийтгэл! – хэмээн орилолдов.

Тэгээд ямар ч тушаалгүйгээр /тушаал өгөх хэн ч байсангүй/ хонхнууд руу ухасхийн түгшүүрийн дохио өгч, ухрах дохио үлээцгээв.

- Хэрэм рүү давхиарай! Хэрэм рүү гүйгээрэй! Толгой дараалан хядуулахгүйн тулд хот руу ороорой хэмээн хэрэм дээрээс хашгиралдацгаав.

Дайсны хөлөг онгоцуудыг тууж яваа салхи тэдний дууг нөгөө тийш нь хөөж байлаа.

Гэвч ийнхүү дохио өгөх, хашгиралдах хэрэг байсангүй. Мустангримчүүд өөрсдөө дайсны онгоцнуудын хар далбааг харлаа. Эомер Харлондаас нэг бээрийн зайд байсан бөгөөд далайн дээрэмчдийн хөлгийг хараад урам зориг орсон хородримүүд боомтын зүгээс давшин тэднийг Дол-Амротын дайчдаас таслав. Эомер Мөрөн рүү хараад, зүрхэнд нь найдварын гал бөхөж,

дайсны талд орсон салхийг хараав. Мордорын цэргүүд баярласандаа бахардах шахан зэрлэгээр бархиралдсаар дайрч байлаа.

Эомерын харц догшин бөгөөд тунгалаг байв. Уур хилэн түүний ухааныг балартуулсангүй. Түүний дохиогоор эвэр бүрээнүүд хүнгэнэж ристаничуудыг эзэнт улсынхаа тугийг хүрээлэн тулалдахыг уриаллаа. Тэрбээр дайчдынхаа ханан хад мэт хүрээлэл дунд эцсээ хүртэл тулалдан Пеленнорын талд Ристанийн сүүлчийн Эзэн захирагчийн гавьяаг магтан дуулах нэг ч хүн үлдэхгүй болсон ч дуунд мөнхрөх гавьяа байгуулахаар шийджээ. Тэр өндөр ногоон толгой дээр дүүлэн гарч, тугаа хатгалаа. Тугны Цагаан морь салхинд дэрвэхдээ агаарт дүүлэн давхиж байх шиг харагдав.

Харанхуй манан дундаас сугарч

Хаяарах үүрийн гэгээ рүү давхисан би,

Хурц илдээ эргүүлж

Мандах нарнаар ялсан би.

Итгэл найдвар эцэслэж, зүрх минь шарх боллоо,

Ирт мэс, эр зоригт заяагаа даатган

Уур хилэн, баатрын үхэл,

Улаан цусаар энэ өдрийг үдэцгээе!

– хэмээн тэр шүлэглээд тачигнатал инээв. Эрч хүч нь оргилсон орь залуу баатар, дайчин ард түмнийхээ сүлд болсон эзэн захирагч түүний зүрхийг Тулааны онгод дахин эзэмджээ. Зах хязгаар нь харагдахгүй замбараагүй олон дайсан руу тэр дахин хараад хөгжилтэй инээн илдээрээ занав.

Тэгснээ мэл гайхаж, хязгааргүй хөөрөн баярласандаа илдээ наранд гялалзуулан өндөр гэгч шидээд эргэн бууж ирэхэд нь шүүрэн атгаад дуулж эхлэв. Хүн бүр Мөрөн рүү ширтэв. Эхний хөлөг Харлонд руу эргэхэд салхи дарвуулыг нь хумиж, хар тугийн оронд Гондорын далбаан дээр байдаг Цагаан мод, түүнийг тойрсон долоон од үзэгдэв ээ. Ийм тугийг, Элендилийн тугийг энэ оронд мянган жил хэн ч үзээгүй билээ. Туган дээрх одод наранд туяа цацруулж, алтан хүрээт мифрил титэм тодрон гялалзав. Арга ч үгүй, Элрондын охин Арвен хатгасан юм чинь!

Араторны хүү Арагорн, Элендилийн угсаа залгамжлагч Элессар хаан ийнхүү Гондорт ирэх нь энэ ээ. Тэрбээр үхдлүүдийн замыг туулаад, Тэнгисийн эргээс Гондорт салхи, ус хоёрыг хөлөглөн иржээ. Ристаничууд баяр бахдлын инээдээ барьж чадалгүй нирхийтэл инээлдэж, илдээрээ даллан, баяр хөөрөө багтааж ядсан хотын дотор бүрээнүүд цууриалж, хонхнууд дүнгэнэлдэв. Мордорын цэргүүд ид шидээр гараад ирсэн Умбарын далайн дээрэмчдийн хөлөг онгоцоор Дайсны дайснууд ирж явааг хараад алмайран аль ч учраа олохоо байж,

зайлшгүй үхэл нэгэнт ирсэн, заяа тавилан нь нэгэнт дууссаныг ойлгов.

Гондорын хороод нар үзэж чаддаггүй троллууд, хулгайч нар, оржуудыг баруун талаас нь хиар цохив. Эомерын морьт дайчид өмнө зүг рүү уулгалан довтолоход хородримүүд сүүл хавчин зугтаж, алх, дөшний хооронд орж байв. Учир нь Харлондын боомт дээрээс Арагорны дайчид ар араасаа үсрэн тулалдаанд орж байлаа.

Тэдний дунд сум тоолон харвагч Леголас, аймшигт сүхээ эргүүлсэн Гимли, тугч Гальбарад, умардын аймшиггүй мөрдөгчид, Элладан, Элроир хоёр, бүгд байсан бөгөөд тэдний араас Лебеннины хэдэн мянган дайчид, Ламедон, тэнгисийн эргийн дайчид олон мянгаараа тулаанд уухайлан орлоо. Бүгдийн өмнө Арагорн дүүлэн довтолж, тэргүүн дээр нь Эленделийн титэм очир эрдэнээр туяаран, гарт нь эрт цагт Нарсил нэртэй байгаад агуу тулаанд хугарч, шинээр давтагдаад Андрил нэртэй болсон домогт илд урьдын адил гал дөл цацруулан эргэлдэж байлаа.

Эомер, Арагорн хоёр тулааны талбар дунд уулзлаа. Тэр хоёр мориноосоо зэрэг үсрэн бууж, илдээ тулан зогсоод бие бие рүүгээ баяртайяа ширтэн зогсов.

- Ингээд бид хоёр Мордорын хар хүчний хоёр талаас цавчилдсаар энд уулзлаа - гэж Арагорн хэлээд – Би энэ тухай чамд Горнбургт урьдчилан хэлснийг чи санаж байна уу?

- Санаж байна аа, чи үнэн хэлсэн байна - гэж Эомер хариулаад – Гэхдээ итгэл найдвар хуурамч байх нь бий, чамайг ирээдүйг хардаг гэж би мэдээгүй. Гэхдээ хүлээгээгүй тусламж хүрээд ирэх үнэхээр сайхан юм, үүнээс илүү баярт үйл явдал надад урьд өмнө тохиолдож байсангүй.

Тэгээд тэр хоёр гараа чанга барилцав.

- Чи яг цагаа олж ирлээ. Дахиад жаахан удсан бол чи хожимдох байлаа. Бид их хохирол амслаа - гэж Эомер хэлэв.

- За яахав, эхлээд хохирлоо нөхүүлбэ, дараа нь ярилцацгаая! - гэж Арагорн өгүүлээд хоёул мориндоо мордож мөр зэрэгцэн тулалдав.

Дахиад удаан тулалдлаа. Хайр найргүй, хатуу ширүүн тулалдаан боллоо. Харгис хэрцгий, хатан зоригт өмнөдийнхөн эцсээ хүртэл үзэлцэж, дорнын битүү сахалт үлэмж биетнүүд ч өршөөл гуйхгүй алалдаж байв. Шатсан эдлэн газарт ч, дов толгод дээр ч, хэрмийн ханын дэргэд ч, задгай талд ч дайснууд үй олноороо хуйларч, газар сайгүй байдаг хүчээрээ улангасан алалдаж, тулалдаан үдшийн бүрий болтол үргэлжлэв.

Эцэст нь нар Миндоллуины цаагуур орж, тэнгэр тэр чигээрээ улайран, уулын бэл цусанд будагдан, их мөрөн гал улаан өнгөтэй болж, Пеленнорын тал жаргах нарны туяанд час улаан харагдаж байв. Гондорын төлөөх агуу тулалдаан ийнхүү төгсч, Раммас-Экорын хязгаарт нэг ч дайсан амьд үлдсэнгүй. Тэднийг бүгдийг нь зүйл дуусгав. Зугтагсдыг хөөн гүйцээд бодийг нь хөглөн, үлдсэн хэсэг нь андуины улаан усанд үйлээ. Магадгүй зарим нэг нь Моргул юм уу, Мордорт амьд хүрсэн байж болох л юм, гэвч хородримын газарт зөвхөн Гондорын хайр

найргүй хядааны тухай дам сураг л хүрчээ.

Арагорн, Эомер, Имраиль хотын хаалгаар ороход гурвуулаа дуугарах ч тэнхэлгүй болтлоо ядарсан байлаа. Гурвуулаа эсэн мэнд, бүрэн бүтэн. Хувь заяа нь тэднийг хамгаалсан юм уу баатрын их хүч, тулааны ур чадвар нь аварсан юм уу бүү мэд. Гэхдээ тоо томшгүй олон дайснаас тэр гурвын өөдөөс тулах зоригтон цөөхөн байсан бөгөөд уур хилэнгээс нь ухаан алдталаа айж, түймрээс зугтаж байгаа юм шиг ухаан жолоогүй зугтааж байлаа. Шархадсан, эрэмдэг зэрэмдэг болсон дайчдыг тоолохын аргагүй, мөн ч олон дайчин энэ их тулаанд амь үрэгджээ. Форлонг олон дайсантай ганцаар явган үзэлцэж байгаад саран сүхэнд цавчуулж, Мортхондын Дуилин дүүтэйгээ мумак мангасуудын нүдийг сум тоолон харваж байгаад тэдгээр аварга биетнүүдэд алагджээ. Цагаан үст Гирлуин Ногоолин толгоддоо эргэж очсонгүй, Гримблад Гримдолдоо буцаж чадсангүй, мөрч Гальбарад умард хязгаартаа буцах тавилангүй байж. Тэр тулалдаан дэндүү хатуу ширүүн байсан тул хэн ч амь үрэгдсэн дайчдын тоог гаргасангүй, алдар цуут баатар вангуудыг ч, нэр нь үл мэдэгдэх дайчдыг ч адилхан мартжээ. Олон жилийн хойно ристанийн нэгэн шүлэгч Мундбургийн булшны дэргэд ийн дуулжээ..

Эвэр бүрээнүүд үүрийн гэгээнээр цууриалсан юм,

Илд, жаднууд өмнийн уудам талд гялалзсан юм,

Уулгалах салхи мэт хурдан морьд

Уулсын оронд давхин ирж, их тулаан эхэлсэн юм.

Тэнгэлийн хүү Теоден тэр тулаанд унаж,

Эрэлхэг Ристанийн хүчирхэг удирдагч тэгээд

Эх нутгийнхаа ногоон тал

Эрдэнийн алтан өргөөндөө

Эргэж хэзээ ч очоогүй юм.

Гардинг, Гутлаф,

Дунгир, Деорвин,

Гримблад, Хорн, Фастред,

Гирфара, Герубранд...

Хайран тэр баатрууд

Харийн газарт тулалдаж,

Мундбургийн булинд хөрст газраар хучуулан,

Мөнхөд амгалан нойрссон юм.

Мөр зэрэгцэн цавчилдсан Гондорын баатрууд

Мөн л тэдэнтэйгээ хамтдаа.

Цагаан үст Гирлуин ялалтын мэдээгээ

Цэцэгт хөндийдөө хүргэж очоогүй.

Өвгөн дайчин ван Форлонг

Өрнийн Лоссарнахдаа очоогүй.

Эрхий мэргэн харваач Деруфин, Дуилин хоёр

Эх нутаг Мортхондын уулстаа

Эргэж хэзээ ч очихгүй.

Хадуур барьсан үхэл өглөөнөөс үдэш хүртэл

Хайр найргүй хяргаж, арвин ургац хураасан юм.

Тэр өдөр Их мөрөн Андуин

Улаан давалгаа хуйлруулж,

Улаан хөөс цахруулж байсан юм.

Тэр шөнө Пеленнорын талд

Улаан шүүдэр буусан юм.

Мөрний саарал ус саарал нулимс адил

Мөнгөлөг туяа татуулан

Мөнхөд урссаар байнам.

Бүлэг 7

Оршуулгын гал

Сүг сүүдэр алга болж, их хаалга онгойн харласан боловч Гэндальф хөдөлгөөнгүй зогссоор байлаа. Пин үсрэн босов. Тэр гинжнээс тавигдсан нохой мэт болж, эвэр бүрээнүүдийн сүрлэг цууриаг сонсон, зүрх нь баярласандаа болоод дэлбэрэх гэж байгаа юм шиг санагдав. Тэр амьдралынхаа сүүлчийн мөчийг хүртэл алсаас цууриатах бүрээн дууг сонсон хөшөө мэт зогсоход бэлэн байлаа. Гэвч тэр гэнэт яах гэж ирснээ санаад ухасхийн гүйлээ. Энэ үед Гэндальф хөдөлгөөн орж, Аянгад нэг юм хэлээд Их хаалга руу хөдлөв.

- Гэндальф, хөөе Гэндальф! - гэж Пин хашгирахад Аянга зогсов.

- Чи энд юугаа хийж яваа билээ? - гэж Гэндальф зандраад: - Эндхийн хуулийг мэдэхгүй гэж үү чи, мөнгөн чимэгт хар хувцастан эзэн захирагчийн зөвшөөрөлгүйгээр Цайзаас гарах ёсгүй бус уу!

- Тэр зөвшөөрсөн, зөвшөөрөх ч гэж, намайг хөөчихсөн. Тэнд ямар нэг аймшигтай юм болох вий гэж айж байна. Миний бодлоор бол эзэн захирагч өөрийн ухаанаа алдсан шиг байна. Тэр өөрийгөө ч, Фарамирыг ч алчих байх гэж би айгаад байна. Чи нэг арга бодохгүй юу?

Гэндальф их хаалганы цоорхой руу харж байв. Тулалдааны чимээ талаас улам тод дуулдаж байлаа.

- Би тийшээ явах хэрэгтэй – гэж тэр хэлээд – Хар морьт одоо эргээд ирнэ, тэгвэл аюулаас зайлах газаргүй болно. Надад цаг алга.

- Тэгээд Фарамирыг яах юм бэ! Тэр үхээгүй байна, гэтэл хэн нэгэн саатуулахгүй бол түүнийг амьдаар нь шатаах гээд байна!

- Амьдаар нь шатаах ий? - гэж Гэндальф асуугаад – Юу яриад байгаа юм бэ чи? Хурдхан хэлээд аль!

- Денэтор Бунхан руу орсон, Фарамирыг хамт аваад орсон, бид хоёрыг галд үй, хуурай мод авчраад тос асгаж, намайг Фарамиртай хамт шатаа гэж тэр тушаасан. Мод, тос авчруулахаар зарц нараа явуулсан. Би энэ тухай Берегондод хэлсэн, гэвч тэр харуулын байраа орхихгүй байх. Тэгээд ч тэр Денэторын өөдөөс юу хийж чадах вэ дээ? – хэмээн Пин давхцуулан дуржигнуулаад, чичирсэн гараараа Гэндальфын өвдгөнд хүрч: - Чи Фарамирыг аварч чадахгүй юу? - гэлээ.

- Чадах байх аа, гэхдээ түүнийг аварч байх хойгуур бусад нь амь үрэгдэнэ гэж айж байна. За за, явцгаая, үүнд надаас өөр хэн ч тусалж чадахгүй. Гэхдээ миний тусламж муугаар эргэж ч магадгүй. Хар шидтэнээс ямар ч хана хэрэм хамгаалахгүй. Дайсан гаднаас биш, дотроос нэвгэрч байна.

Тэрбээр ингэж шийдэнгүүт цаг алдсангүй, Пинийг шүүрч аваад урдаа суулгаж, Аянгад нэг юм хэлэв. Тэднийг Минас-Тиритийн гудамжаар дээш давхихад ар талд нижигнэх чимээ улам ихэссээр байв. Энд тэндгүй айж, цөхөрсөндөө аргаа барсан хүмүүс гэнэт сэргэж, зэвсгээ шүүрцгээн, бие биедээ “Мустангримчүүд ирлээ!” хэмээн хашгирцгааж байв. Жанжингуудын захирах дуу сонсдож, дайчид жагсан эвдэрсэн хаалга руу яарцгааж байлаа.

Тэднийг харсан Имраилийн хаан:

- Чи хаачих нь вэ, Митрандир? Мустангримчүүд ирчихээд Гондорын талд байлдаж байна! Бид бүх хүчээ бөөгнөрүүлэх хэрэгтэй байна! – гэлээ.

- Бүх дайчдыг нэгийг ч үлдээлгүй гарга! Нэг ч мөч хором алдаж болохгүй! Би аль болохоор хурдан очно, одоо надад эзэн захирагчтай ярилцах хойшлуулшгүй ажил байна. Бүх цэргийг захирч бай! – гэж Гэндалф тушаав.

Гол цайзын дэргэд, өндөрт гараад ирэхэд өмнөөс нь салхи үлээж, тэнгэрийн дорно хаяанаас нар хөөрч байлаа. Гэвч тэдэнд өглөө боллоо гээд баярлах юм бага байв. Зөн совингоороо нэг л муу юм мэдэрч, хожимдохгүйг хичээн хурдаллаа.

- Харанхуй сарниж байна, гэвч хотод харанхуй хэвээрээ - гэж Гэндалф хэлэв.

Цайзын хаалган дээр харуул алга байлаа.

- Аа, Берегонд тийшээ явчихаж - гэж Пин хэлээд санаа нь амрах шиг болов. Тэд Түгжээтэй хаалга руу очих замаар эргэлээ. Хаалга цэлийтэл нээлттэй, манаач нь алагдсан хэвтэж байв. Түүний түлхүүрийг авсан бололтой.

- Дайсан харах юм бол ёстой нэг баярлана даа! Ийм л юм тэрэнд таалагдана. Өөр хоорондоо алалцаж байдаг, тэхдээ аль аль нь өөрийнхөө үүрэгт өөрийнхөөрөө үнэнч байна – гэж Гэндалф хэлэв.

Тэр хоёр бууж, Аянгыг жүчээ рүү нь явуулав.

- Найз минь, чи бид хоёр өдийд тулааны талбарт хийсгэж явах байлаа, гэтэл саатах хэрэг гарчихаад байдаг. Би одоохон чамайг дуудна аа! – гэж Гэндалф Аянгад хэлэв.

Тэр хоёр хаалгаар орж, огцом тахирласан замаар уруудлаа. Гэгээ орж, өндөр өндөр багана болон хөшөөнүүд хий үзэгдлийн жагсаал мэт харагдана.

Гэнэт нам гүмийг хүмүүсийн хашгиралдах, илдний хангинах дуун эвдэв. Энэ хотыг байгуулснаас хойш өнөөг хүртэл хэзээ ч хаадын бунхны нам гүмийг ийнхүү эвдэж байсан удаагүй билээ. Мань хоёр Раг-Динен хүрч, хаадын бунхан руу яарав. Түүний өндөр гонх бүрэнхийд бүдэгхэн харагдаж байлаа.

- Больцгоо! Больцгоо! - гэж Гэндалф чулуун довжоон гүйн гараад: - Больцгоо, галзуураа юу, та нар хэмээн зандрав.

Дээд гишгүүр дээр цайзын хамгаалагчийн мөнгөлөг хар өмсгөлтэй Берэгонд гартаа илд, дэнлүү барьсан Денэторын зарц нартай үзэлцэж байна. Хоёрыг нь аль хэдийн тасар цавчжээ. Үлдсэн зарц нар нь үймэн дэгдээгч, урвагч Берэгондыг аль муугаар хараан дайрч байлаа.

Гэндальф, Пин хоёрт бунхан дотроос хилэгнэн хашгирах Денэторын дуу сонсдов.

- Түргэлээч ээ, түргэлээч! Юу болоод байгаа юм бэ? Урвагчийг ал! Надгүйгээр чадахгүй нь үү та нар? - гээд Берэгонд зүүн гараараа дарж байсан хаалга нээгдэж, аймаар сүртэй Эзэн захирагч илдээ далайсаар гарч ирэв. Түүний нүд гялалзаж байлаа.

Гэвч Гэндальф шатаар дээш гүйн гарч ирэхэд, нүд сохлом хурц цахилгаан цахих шиг болоод зарц нар гараараа нүүрээ хаан ухрав. Гэндальф гараа хилэнтэйгээр өргөхөд Денэторын илд бунхны харанхуй булан руу хөсөр унаж, Денэтор алмайран арагшаа алхам ухарлаа.

- Энд чинь юу болж байгаа юм бэ, эзэнтээн? Булшин дотор амьд хүн байдаггүйсэн биш үү? Яагаад бүх дайчид тулааны талбарт очиж байхад энд илд гялалзаж байдаг билээ? Эсвэл Дайсан аль хэдийнэ энд, Рат-Диненд ороод ирсэн юм уу?

- Хэзээнээс Гондорын эзэн захирагч чиний өмнө хариуцлага хүлээдэг болсон юм бэ? – гэж Денэтор хариулаад – Магадгүй, бас миний зарц нар надад захирагдахгүй юу?

- Захирагдах нь ч захирагдана, гэвч чиний ухаан балайрч, уур хилэнд эзлэгдвэл чиний эрх мэдлийг байхгүй болгож болно. Чиний хүү Фарамир хаа байна?

- Бунханд хэвтэж байгаа, түүнийг дотроос нь гал шатааж байна. Удахгүй бид бүгдээрээ шатна. Өрнөд өнгөрсөн, түүнийг агуу их гал залгиж, бүх юм төгсгөл болно. Зөвхөн үнс л үлдэнэ! Үнс утаа хоёрыг салхи тууж одно!

Гондорын эзэн захирагч үнэхээр эрүүл ухаанаа алдсаныг Гэндальф үзээд Фарамир руу яарав, Берэгонд, Пин хоёр араас нь салалгүй дагаж, Денэтор ширээнд хүртэл тэднийг гүйцсэнгүй. Фарамир урьдын адил ухаангүй хэвтэж байв. Ширээн доогуур болон эргэн тойронд хагалсан түлээний мод овоолон, дээрээс нь маш их тос асгажээ, Фарамирын хувцас, хөнжил дээр ч их тос асгажээ. Гэндальф гэрэл тээгч их хүчээрээ хар саарал хараалт хүчийг ялж байсантайгаа адил дотоод нууц хүчээ гаргав. Тэрбээр овоолттой модон дээр үсэрч гараад Фарамирыг хөнгөхөн өргөж, доош үсрэн буугаад хаалга чиглэв. Фарамир гэнэт ёолж, халуундаа солиорон эцгийгээ дуудав.

Денэтор гэнэт сэрэх мэт болж, нүднийх нь гал унтраад, нулимс цувуулан:

- Миний хүүг надаас бүү салга! Тэр намайг дуудаж байна- гэв.

- Тийм ээ, чамайг дуудаж байна. Гэхдээ чи түүн рүү ойртож болохгүй - гэж Гэндальф хэлээд – Тэр үхлийн үүдэн дээрээс амьд эргэх тусламж гуйж байна. Олох эсэхийг би мэдэхгүй байна. Харин чи бүслэгдсэн хотынхоо төлөө тулалдаж, үхлийн өөдөөс сөрөн гарах хэрэгтэй. Өөрөө сайн мэдэж байгаа шүү дээ.

- Үгүй ээ, тэрэнд одоо туслах нэгэнт оройтсон, байлдаад ч яах юм билээ. Хэрэггүй амьдралыг юуны төлөө сунгах юм? Хамтдаа үхсэн нь дээр биш үү?

- Чи үхэх өдөр цагаа урьдаас хэлдэг шидтэн биш эзэн захирагч минь, эртний их эзэд л хар хүчнүүдэд захирагдан тэр цагийг заадаг байсан юм, тэд бардам зан, цөхрөл хоёроос болж, өөрийгөө төдийгүй хамгийн ойрын төрлөө ч алдаг байсан юм - гэж Гэндальф түүнд хэлэв.

Тэгээд Гэндальф Фарамирыг бунхнаас гаргаж, түүрүүнд түүнийг тавьж авчирсан лоожин дээр тавив. Денэтор араас нь гарч ирээд хүүгийнхээ царайнаас нүд салгалгүй ширтэж, салгалан зогсов. Бүгд эзэн захирагчийн юу гэж хэлэхийг хүлээн чив чимээгүй зогсов.

- Явцгаая! - гэж Гэндальф хэлээд – Биднийг аль хэдийнээс тэнд хүлээж байна. Чи тулааны талбарт хэрэгтэй байна –гэлээ. Денэтор гэнэт тачигнатал хөхрөв. Тэрбээр өндөр чилгэр нуруугаа бардмаар эгцлэн гантиг ширээ рүү хурдан алхлан очиж, дэрээ аваад хаалга руу очиж задлахад түүний гарт Нүдэн чулуу байхыг бүгд харав. Тэр чулууг дээш өргөхөд чулуунаас галын гэрэл цацарч, эзэн захирагчийн нүүрийг гэрэлтүүлэв. Түүний нүүр гантигаар цохиж хийсэн юм шиг хатуу, ихэмсэг бөгөөд аймшигтай харагдав. Түүний нүд дахин гялалзлаа.

- Бардам зан, цөхрөл хоёроосоо болдог гэж чи хэлэв үү! Цагаан цамхгийн цонх сохор гэж чи бодож байсан уу? Би эндээс хичнээн их зүйл харж байсныг Саарал тэнэг чи яаж мэдэхэв дээ. Чиний итгэл найдвар чинь мэдэхгүйгээсээ болж байгаа юм. Явж, хагас үхдлүүдийг эмчил! Ялагчидтай очиж тулалд! Аль нь ч хэрэггүй. Нэг хоёр өдөр тулалдаад ялж болох л юм. Гэвч та нарын дээрээс ирэх цохилтыг няцаах аргагүй. Минас-Тирит руу ганцхан жижиг сарвуу л сарвайсан юм. Дорнын цэргийг тоолж барахгүй. Чи одоо ч гэсэн салхинд туугдан Андуйнаар өгсч байгаа хар далбаатай онгоцнуудыг хараад баярлаж тэнэгтэж байгаа ч гэсэн ялахгүй. Өрнөд дууссан! Боолын үхлээр үхэхийг хүсээгүй бүхэн одоо амьдралтай аль болохоор хурдан салах ёс гүйцэтгэх хэрэгтэй.

- Ийм яриа Дайсанд үнэхээр таалагдана, үнэхээр түүнд ялалтыг өгч магадгүй юм шүү -гэж Гэндальф хэлэв.

- Чи найдаж л бай! - хэмээн Денэтор хөхрөөд: - Би чамайг нэвт харж байна, Митрандир! Чи миний оронд захирагч болж, умард, өмнөд, өрнөдийн хаан ширээг сэмхэн эзэгнэхийг горьдож байгаа. Гэвч чиний бүх далд санааг би таасан. Чи энэ муу одой биетэд хэлээ сайн хавчиж бай гэж тушаасныг чинь би мэдэхгүй гэж бодож байна уу? Чи энэнээр намайг тагнуулах гэж ордонд орхисныг чинь мэдээгүй гэж бодож байна уу? Гэвч би үүнээс чиний дагуулуудын чинь тухай бүх үнэнийг мэдэж авсан. Тийм шүү! Чи зүүн гараараа намайг Мордороос хамгаалах бамбай болгоод, баруун гараараа умардын Мөрчийг татаж авчраад их хааны ширээнд суулгах гэж байгаа!

Үгүй дээ, Митрандир ч гэнэ үү, Гэндальф ч гэнэ үү, өөр хэн ч гэж дууддаг юм надад хамаагүй! Би бол Анарионы удмын тавьсан эзэн захирагч, би ямар нэг тохиолдлын амьтны тэнэг зарц болохгүй. Хэрэв тэр үнэхээр залгамжлагч мөн байлаа ч гэсэн ердөө л Исилдурын холын удам. Аль дивангарт эрх мэдэл, нэр хүндээ алдсан тэр омгийн нэг орхидос надад ямар хамаа байна?

- Чинийхээр бол яах ёстой байсан юм бэ? - гэж Гэндальф асуув.

- Бүх юм миний захиргааны үед байсан чигээрээ үргэлжлэхийг би хүсч байна. Миний эртний өвөг дээдсийн үеэс өнөөг хүртэл ямар байсан, тэр л чигээрээ байхыг хүсч байна – гэж Денэтор хариулаад - Би Гондорыг амар тайван захирсан хэвээрээ байхыг хүссэн, миний залгамжлагч нэг илбэчний үгээр явахгүй өөрөө өөртөө эзэн болсон хүү минь байхыг хүссэн юм. Хэрэв хувь заяа миний энэ хүслээс татгалзаж байгаа бол би юу ч хүсэхгүй – адлагдсан амьдрал, хассан хайр, доромжлогдсон нэр төрийн аль нь ч надад хэрэггүй.

- Хууль ёсны эзэн хаан эргэж ирэхэд яахаараа үнэнч эзэн захирагчийг адалж, хасч, доромжилсон болохыг би ойлгохгүй байна - гээд Гэндальф - Чиний хүү одоохондоо амьд байна, чи түүний өмнөөс шийдэх эрхгүй - гэлээ.

Ингэж хэлэхэд Денэторын нүд оч үсчүүлэх мэт гялалзав. Тэр чулуугаа сугандаа хавчуулаад, кинжаалаа сугалан лоож руу ухасхийв. Гэвч Берегонд түүний урдуур үсрэн орж Фарамирыг хамгаалав.

- Аан, ингэдэг юм би! - гэж Денэтор хашгираад: - Чи миний хүүгийн эцгээ гэсэн хайрын хагасыг хулгайлсан чинь багадаад, миний зарц албатуудыг өөртөө татсан байх нь ээ. Гэвч чи нэг зүйлээр надад саад болж чадахгүй, би үхэх ёсоороо л үхнэ!.. Над руу! Та нараас урваагүй үлдсэн хүн байвал над руу ир! – гэж зарц нараа захирав.

Тэдний хоёр нь эзэн рүүгээ гүйж очлоо. Денэтор нэгнийх нь бамбарыг шүүрч аваад, бунхан руу буцаж ухасхийв. Гэндальф түүнд саад хийж амжсангүй. Тостой хуурай мод нижигнэсэн их чимээ гарган дүрэлзэв.

Денэтор ганцхан харайгаад ширээн дээр гарч, очироо авч өвдгөн дээрээ хугалаад гал руу шидэв. Тэгээд хоёр гараараа Нүдэнчулууг энгэртээ тэврээд түрүүлгээ харан хэвтэв.

Дараа нь тэрхүү Нүдтэй чулууг хэн нэгэн харсан бол, эзэн захирагч тэр чулууг эзэмших онцгой эрхт эзэн биш байсан бол чулуун дээр зөвхөн өтөл өвгөний махир хурууны үнс л харагдах байсан гэж ярьцгаадаг билээ.

Харуусал, үзэн ядалтад цочирдсон Гэндальф арагш ухарч, хаалгыг хаав. Тэрбээр босгоны дэргэд таг дуугүй, бодолдоо автан зогслоо. Бунхан дотор дүрэлзэж байгаа галын сүрлэг чимээ бүгдэд сонсдоно. Тэгснээ нэгэнтээ аймшигтай хашгирах сонсдоод түүнээс хойш газар дээр Денэторыг дахин үзэж, сонссон хэн ч гараагүй гэдэг.

- Эктелионы хүү Денэторын төгсгөл ийм болов - гэж Гэндальф хэлээд Берегонд болон айдаст автан хөдөлж ч чадахгүй байгаа зарц нар руу харав.

- Ингээд та нарын амьдарч байсан тэр Гондор орон түүнтэй хамт өнгөрсөн үе рүү одлоо. Сайн уу, муу юу бүү мэд, гэвч тэрний цаг дууслаа. Энд цус урссан, гэвч та нар уур хилэнгээ дарж, өшөө хонзон бүү сана. Үүнд та нарын буруу байхгүй, энэ бол хар шидийн хараал жатга. Дайсны хорон санааны торонд орооцолдох юм бол өргөсөн тангарагтаа үнэнч байх хүртэл хор хөнөөлтэй болдог юм байна. Эзнийхээ үнэнч зарц нь байсан, түүнд сохроор захирагдаж

байсан та нар бодоод үз. Хэрэв Берегонд эзнээсээ урваагүй бол Цагаан цамхгийн жанжин Фарамир эцэгтэйгээ хамт шатаж үхэх байлаа.

Амь үрэгдсэн нөхдөө энэ муухай Аниргүйн гудамжнаас авч гарга. Бид одоо Гондорын эзэн захирагч болсон Фарамирыг нэг бол сэргэж босох, нэг бол үүрд нойрсох газар руу нь авч явлаа – гэж Гэндалф захирав.

Тэгээд Гэндалф, Берегонд хоёр лоожийг өндөр өргөн бунхнаас холдож, Анагаах танхим руу явахад Пин араас нь толгой гудайн дагав. Эзэн захирагчийн зарц нар бунхнаас нүдээ салгаж чадахгүй, хөшсөн мэт зогссоор. Гэндалф нар Рат-Диненээс өнгөрч явахад ар талд битүү нүргээн сонсогдлоо. Эргэж харвал бунхны орц гал утаан дунд нуран унаж үзэгдэв. Зарц нар сэхээ орж, нөхдийнхөө цогцсыг аваад Гэндалфын араас яарав.

Фен-Холленд хүрээд Берегонд алагдсан манаач руу гүнээ харамсалтай харлаа.

- Би ийм юм хийсэндээ өөрийгөө хэзээ ч уучлахгүй, гэвч би яарсандаа бараг ухаангүй шахам явсан, харин тэр миний үгийг сонсохыг ч хүсээгүй шууд илд сугалсан – гэж тэр хэллээ.

Тэгээд манаачаас авсан түлхүүрээ гаргаж хаалгыг түгжив.

- Энэ түлхүүрийг одоо манай эзэн хаан Фарамирт өгөх ёстой – гэж тэр хэлэхэд:

- Одоохондоо түүнийг Дол-Амротын жанжин орлож байгаа, гэвч тэр одоо тулалдаж байгаа, энд би захирна. Түлхүүрийг өөртөө үлдээж, хотод эмх журам тогттол хадгал - гэж Гэндалф хэллээ.

Эцэст нь тэд хэрмийн дээд давхарт гарч, өглөөний гэгээн дундуур Анагаах танхим хэмээн нэрлэсэн гоёмсог өргөөнд хүрэв. Урьд нь энд хүнд өвчитнүүдийг эмчилж байсан ба одоо хүнд шархтануудыг эмчилж байгаа ажээ. Энэ өргөө нь гол цайзын хаалганаас холгүй, өмнөд хэрмийн зургадугаар давхарт байрласан бөгөөд дэргэд нь цэцэрлэг болон төгөл байгаа нь Минас-Тиритэд тун ховор юм байв. Хотод үлдэхийг зөвшөөрсөн эмэгтэйчүүд тэнд ажиллаж, эмчилгээнд тусалдаг, маш сайн асрагчид байлаа.

Гэндалф, Берегонд хоёр Танхимын гол хаалганд хүрч, лоожийг буулгаж байтал байлдааны талбараас, доод хаалганы орчимд зүрх чичрүүлж, чих янгинуулсан аймшигтай орилоон сонсдов. Тэр орилооныг салхи авч одон тэнгэрийн хаа нэгтээ чимээгүй болов. Дэндүү аймшигтай орилоон байсан тул мань гурав хоромхон зуурт балмагдсан боловч чимээгүй болсных нь дараа цээж дүүрэн амьсгаллаа. Дорно зүгээс харанхуй мөлхөж ирснээс хойш тэд ийм сайхан чөлөөтэй амьсгалж байсан удаагүй билээ. Нар үүлэн цаанаас сугаран гарч тунгалаг өглөө боллоо.

Гэвч Гэндалфын царай ширүүн бөгөөд гунигтай байлаа, тэр Фарамирыг Танхимд оруулж хэвгүүл гэж Берегонд, Пин хоёрт тушаагаад өөрөө ойрын хэрэм дээр гарч, өглөөн нарны туяанд сүрлэг цагаан хөшөө мэт зогсоод алсыг харж байлаа. Газрынхантай харьцуульшгүй хурц нүдэнд нь байлдааны талбарт болж байгаа бүхэн тод үзэгдэж байв. Эомер дайчдаа орхиод газарт тэрийн хэвтэж байгаа баатрууд дээр очиход, Гэндалф хүндээр санаа алдаад,

цуваа битүүлэн хэрэмнээс буув. Берегонд, Пин хоёр удалгүй гарч ирэхэд тэр хаалганы дэргэд бодолд автан хүлээж байв.

Мань хоёр түүнийг гайхан харж байтал тэр эцэст нь нам гүмийг эвдэж:

- Андууд минь! - гээд - Чи бол Гондорын нийслэлийг хамгаалагч, харин чи бол өмнөд газрын жижигхэн оршин суугч! Дөнгөж сая агуу их уй гашууны үнээр агуу их гавья байгууллаа. Би уйлах уу, баярлах уу гэдгээ мэдэхгүй байна? Тэр аймшигт галзуу дайсан алга болно гэж бид найдаж ч зүрхэлдэггүй байсан. Гэвч саяны тэр орилоон тэрнийг ор мөргүй алга болсныг мэдээллээ. Бидэнд маш том гарз тохиолдлоо. Хэрэв Денэтор солиороогүйсэн бол би тийм гарз гаргахгүй байсан. Дайснаас хэрэмд нуугдана гэж байхгүй. Гэхдээ би одоо тэр хамгийн хүчирхэг цайзад яаж нэвтэрснийг нь мэдэж авлаа.

Энэ Цагаан цайзад тэр долоон нүдэн чулууны ядаж нэг нь байх ёстой гэж би эртнээс таамаглаж байсан юм. Эзэн захирагчид энэ бол агуу их нууц гэж боддог байсан нь алдаа болжээ. Нэг хэсэг Денэторт нүдэн чулуунд хамаагүй хүрч болохгүй, Сауоронтой өрсөлдөж болохгүй гэж ойлгох мэргэн ухаан байсан. Тэр өөрийнхөө хүчийг эрүүл саруул үнэлдэг байсан. Гэвч цагийн аясаар мэргэн ухаан нь бүүдгэрч, Гондорын дээгүүр хар аюул нөмрөхөд тэр чулуунд харсан, хараад л хууртагдаад байсан байж таарна, Боромирыг явнаас хойш дэндүү олон харсан байх гэж айж байна. Барад-Дур түүнийг хар шидээрээ захирч чадаагүй боловч, чулуунд харах бүртгээ харуулахаар бэлдсэн юмыг нь л хардаг байж. Тэр багагүй юм мэдэж байсан, бүр дэндүү олон зүйл ч мэддэг байсан байж магадгүй, гэхдээ Мордорын замбараагүй их хүчтэйг хараад тэр цөхөрч, саруул ухаанаа алдсан байна.

- Одоо л би ойлголоо, харин тэгэхэд үхтлээ айсан юм! – гэж Пин дуу алдав: -Тэгэхэд тэр Фарамирын хэвтэж байсан өргөөнөөс гараад нэлээд удсаны дараа орж ирсэн юм, ямар хачин өөр болчихоо вэ гэж би бодсон: - Бүр зөнөчихсөн, цөхөрчихсөн орж ирсэн.

- Фарамирыг Цамхагт оруулснаас хойш нэг цагийн дараа Цамхгийн дээд цонх гэнэт гэрэлтэхийг манай олон хүн харсан байсан - гэж Берегонд хэлэв: - Гэхдээ ийм явдал урьд нь ч болдог л байсан, эзэн захирагч Дайсантай халз тулалддаг тухай сураг эртнээс гарсан юм.

- Тэгэхлээр миний таамаглалууд үнэн боллоо – гэж Гэндалф хэлээд - Саурон Минас-Тиритэд ингэж л орж ирсэн, намайг ч саатуулж чадсан юм байна. Би одоохондоо энд байхаас өөр арга алга. Фарамирын араас бусад шархтнуудыг авчирна.

Доод хаалга руу бууж тэднийг угтаж авах хэрэгтэй. Талд болсон үйл явдлыг харахад надад маш харамсалтай байлаа, түүнээс ч илүү харамсалтай юм болох вий гэж л айж байна. Пин надтай хамт яв! Харин Берегонд чи цайзад очиж, болсон бүх явдлыг даргадаа илтгэ. Одоо чамайг Цагаан цайзын хамгаалагчаар авахгүй болов уу гэж айж байна. Гэхдээ хэрэв тэр зөвшөөрвөл Анагаах танхимд илгээнэ үү гэж гуйгаад үз – Энд ч гэсэн хамгаалалт хэрэгтэй, Гондорын эзэн захирагчийг харж хамгаалах хэрэгтэй болно. Хэрэв тэр ухаан орвол дэргэд нь чи байвал сайнсан, учир нь чи түүнийг хэнээс ч илүүгээр галт үхлээс аварсан шүү дээ. Яв! Би удахгүй эргээд ирнэ.

Ингээд Пин тэр хоёр гудамжаар доош буув. Борооны саарал дуслууд гялалзан, гал түймрийг

намдааж, хот утаан үүлэнд бүрхэгдэв.

Бүлэг 8

Анагаах танхим

Меррийн нүдийг нулимс бүрхэж, Минас-Тиритийн эвдэрхий хаалганд дөхөж ирэхэд ядарсандаа сөхрөх шахаж байв. Тэр энд тэндгүй хөглөрөх хүүр, эвдэрч хэмхэрсэн элдэв юмыг огт анзааралгүй, дундуур нь явж байв. Утаа бүрхэж, хиншүү хярвас ханхлан, цамхгууд, хүмүүс, орхууд, өмнөд хязгаарын аварга том араатнуудын хүүр гүйцэд шатаж байлаа. Мортхондын эрэлхэг мэргэн харваачид тэдгээр араатнуудын нүдийг алдалгүй харваж, том том чулуугаар цохин унагааж байсан билээ. Бороо зогсч, нар тэнгэрт үзэгдсэн ч хот угаан саарал мананд дараастай хэвээр. Хүмүүс хотоос гарч, талбайг цэвэрлэн, тулалдаанаас үлдсэн хогийг булж, шатааж байлаа. Тэрэгнүүд ирж, Эовиныг өдөн дэрнүүд дээр эвтэйхэн тавьж, эзэн захирагчийг улаан утаст бүтээлгээр бүтээв. Цувааны өмнө бамбар барьсан хүмүүс явж, нарны цайвар гэрэлд бамбарын гэрэл салхинд дайвалзана. Тийнхүү Теоден, Эовин хоёрыг хотод оруулж ирэхэд, тааралдсан бүх хүмүүс малгай, дуулгаа аван, гүнээ мэхийн ёсолж байв. Утаа, үнсэн дундуур нэгдүгээр давхрыг өнгөрч, төгсгөлгүй урт гудамжаар дээш өгслөө. Ингээд л эцэс төгсгөлгүй өгсч байх юм шиг, сэрэхгүй зүүд зүүдэлж байгаа юм шиг, ямарч ой ухаанд оршгүй үл мэдэгдэх төгсгөл рүү ингээд л яваад л, яваад ль яваад л байх юм шиг Меррид санагдана. Бамбарын галууд тэртээ холд дахин гялсхийж, тэр харанхуйн дунд гэлдэрч явахдаа. “Энэ нарийхан зам булш руу орно, тэнд л амарч авья” гэж бодож байв. Гэнэт түүний зүүдэн мананг нэвтрэн хэн нэгний цовоо дуу хоолой сэрээв.

- Мерри, эцсийн эцэст! Ямар ч гэсэн олдлоо гэм хөөе!

Тэр харцаа дээш өргөхөд угаан хөшиг бага зэрэг шингэрч байв. Түүний өмнө Пин зогсч байв! Нарийхан гудманд хоёулхнаа, өөр хэн ч байхгүй. Тэр нүдээ арчив.

- Эзэн ван хаана байна? Эовин хаана байна? – гэж асуугаад, дахин бүдэрч, довжоон дээр суугаад, дахиад л уйлав.

- Тэд дээр, цамхагт байгаа. Чамайг явдал дундаа унтаад хаашаа ч хамаагүй явчихсан байх гэж бодлоо шүү. Чамайг алга байгааг хараад Гэндальф намайг явуулсан юм. Олоод ир, түүнгүйгээр бүү ир гэж тушаасан. Хөөе, Мерри, хөгшөөн! Чамайг хараад би ямар их баярлаж байна аа! Гэвч чи хөл дээрээ тогтож чадахгүй шахам байхад би чалчаад байдаг. Яасан бэ, бие чинь муу байна, шархдаа юу?

- Үгүй ээ, шархдаагүй л юм шиг байна, гэхдээ Пин минь, ойлгож байна уу, би түүн рүү илдээ дүрэхэд баруун гар мэдээгүй болчихсон. Илд маань ч нарийхан мөчир шиг хайлчихсан.

Пин түүн рүү түгшүүртэй хараад.

- Сонсч бай, хурдан явцгаая, харамсалтай нь би чамайг үүрч даахгүй, ер нь чи явж чадахгүй юм байна даа, гэхдээ уучлаарай. Хотод юу болж байгаа нь мэдэгдэхгүй аймшигтай юм болж байна. Нэг шархадсан хоббитыг санамсаргүй харахгүй өнгөрөх юу ч биш.

- Чамайг анзаарахгүй өнгөрөх бас юу ч биш. Намайг яг харахгүй өнгөрүүлчихсэн юм ... Үгүй ээ, энэ тухай ярих хэрэггүй. Туслаарай, Пин! Гар огт мэдээгүй болчихлоо, нүд бүрэлзээд байна.

- Намайг түшээд яв найз минь! Явъя явъя! Аяархан, алхам алхмаар, энүүхэнд ойрхон байгаа.

- Оршуулгын газар хүртэл үү?

- Юуны чинь оршуулгын газар! – Анагаах танхим – гэж айсан, өрөвдсөндөө бараг уйлах шахан байж Пин цовоо дуугаар хэлэв.

Тэр хоёр өндөр байшингууд болон дөрөвдүгээр хэрмийн хананы хоорондын нарийхан гудамжнаас гарч, цамхаг хүрэх гол гудамж руу оров. Алхам алхмаар арай ядан урагшилж, Мерри унах дөхөн найгаж, зүүдэлж буй юм шиг бувтнана.

“Би хүргэж чадашгүй нь, туслах хүн гараад ирээсэй, гудамжинд орхиод явж болохгүй” – гэж Пин бодов.

Тэгтэл гайхамшигтай тохиолдол болж, хойноос Бергондын хүү Бергил гүйгээд ирэв.

- Сайн уу, Бергил! – Хаашаа яарч явна? Аавыгаа баярлуулаад амьд мэнд гүйж явааг чинь харж байна!

- Би анагаагчдын даалгавраар явж байна, чамтай ярилцах зав алга

- За гүй, гүй! – харин над шиг нэг жижигхэн хүн байлдааны талбараас арайхийн энд ирсэн, цаашаа явж чадахгүй байна, шархадсан юм гэж хэлээрэй. Митрандир тэнд байвал түүнд хэл, тэр баярлана шүү.

Бергил гүйж одлоо.

“Энд л хүлээ” - гэж Пин бодоод Мерриг зам дээр нартай газарт буулгаж, дэргэд нь суугаад толгойг нь өвөр дээрээ тавилаа. Дараа нь түүний хөлөөс нь толгой хүртэл тэмтэрч үзээд, гарыг нь атгав. Баруун гар нь мөс шиг хүйтэн байв.

Тун ч удалгүй өөр хэн нэг хүн биш, Гэндалф өөрөө хүрээд ирэв. Тэр Меррийн дээрээс тонгойж, духан дээр нь алгаа тавиад, дараа нь эвтэйхэн босгов.

- Энэ дайчинг өндөр хүндэтгэлтэй угтаж авах хэрэгтэй байлаа, тийм ээ, би та нарыг зөв таньсан байна, хэрэв Элронд миний үгийг аваагүй бол, та хоёрыг хоёуланг нь аян дайнд явуулаагүй бол энэ өдрийн тулалдаан хавьгүй гунигт үр дүнтэй болох байлаа – гээд шидтэн санаа алдаж. - Гэвч одоо миний гар дээр бас нэг шархтан байна, дайн юугаар төгсөх нь хараахан тодорхой бус байна гэлээ.

Анагаах өргөөнд Фарамир, Эовин, Мериадок гурвыг хамгийн дээд хэмжээнд эмчилж байлаа. Учир нь эртний шинжлэх ухааны болон урлагийн олон үнэт зүйлсийг алдсан боловч гондорын эмч нар урьдын адил эгнэшгүй хүчтэй хэвээрээ. Тэд бүх төрлийн шархыг чадварлаг

эдгээж, Минас-Тиритээс Тэнгис хүртэлх энэ хязгаарт хүмүүсийн өвчилдөг бүх өвчнийг анагааж байлаа. Зөвхөн өтлөлтийг л зогсоож чаддаггүй байв. Түүнээс хамгаалах эм олдоогүй, тэгээд ч гондорчууд бусдаас урт насалдаггүй байлаа. Эртний цэвэр цусны омгуудаас л цөөн хүн зөнөлгүйгээр зуу хүртэл насалж байв. Хар өвчин хэмээх нэртэй нэг л шинэ өвчнийг хамгийн гарамгай эмч нар ч анагааж чадахгүй байлаа. Учир нь тэр өвчин хар үхдэл сүгнүүдээс үүсэлтэй байв. Ийм өвчтэй хүмүүс улам л бөх унтсаар байгаад, нойрондоо хөшиж, нас бардаг байжээ. Энэ өвчин Анагаах өргөөнд хүргэж ирсэн жижиг биет болон ристанийн хатан хаанд туссан нь илт байв. Тэр хоёрыг эмч нар шууд л “найдваргүй” гэж оношлов. Тэр хоёр өдөр болохоор нойрон дундаа ярьж эхэлдэг, сахиурууд үг бүрийг нь барьж авдаг байв, гэнэт ямар нэг чухал юм хэлэх ч юм бил үү. Гэвч нар баруун тийш ташаад ирэхээр амьгүй мэт бөх унтаж, нүүрэн дээр нь саарал сүүдэр гарч ирдэг байв. Фарамир хоромхон зуур ч зогсосхийлгүй шатаж буй мэт халууран дагждаг байв.

Гэндальф нэг орноос нөгөөд зогсолтгүй явж, сахиулууд түүнд бүх зүйлийг нэгд нэггүй илтгэнэ. Ийнхүү нэг өдөр өнгөрч. Хотын хана хэрмүүдийн доорх агуу их тулалдаан нэг ширүүсч, нэг намдан, дайны талбараас түгшүүртэй, авцалдаа муутай мэдээнүүд ирж байлаа. Шидтэн шархтнуудыг орхиж төвдөлгүй асарсаар байтал жаргах нарны улаан туяа тэнгэрийг будан, шархтнуудын саарал нүүрэнд туяа тусав. Тэдний царай үл мэдэг ягаарах шиг болсон авч энэ бол ердөө л найдварын хий үзэгдэл байлаа.

Энд үлдсэн эмэгтэйчүүдийн хамгийн ахмад, Иорета удган үхэж байгаа Фарамирын гоо сайхан царай руу хараад уйлж.

- Тэр үхэх юм гэж үү! Эзэн хаан Гондорт эргээд ирдэг ч болоосой! Эрт дээр цагт манайд эзэн хаад байсан шүү дээ, эртний нэг үг байдаг юм. “Эзний гарт эмчлэх хүч бий” гэж. Жинхэнэ эзэн хааныг тэр хүчээр нь таньдаг байсан гэдэг.

Удганы дэргэд зогсч байсан Гэндальф.

- Чиний энэ үг алтан үг байна шүү, Иорета, энэ үгийг чинь хүмүүс их удаан санаж явах болно оо! Яагаад гэвэл энэ үг итгэл найдвар төрүүлж байна. Үнэхээр эзэн хаан Гондорт эргээд ирэх юм биш биз? Чи ямар нэг юм сонсоогүй биз дээ?

- Юу эсийг ярьдаг билээ, ярихаасаа хашгирах нь их, надад сонсч суух зав байх биш. Энэ дээрэмчид манай энд л битгий ороод ирээсэй билээ, шархтнуудыг л битгий түгшээгээсэй билээ!

Гэндальф яаран гарахад нар жаргаж, хотын хаалган дээр Арагорн, Эомер, Имраиль, бусад жанжингууд, баатар вангууд ирцгээв. Арагорн хэлэв.

- Хараач, нар ямар час улаан өнгөөр жаргаж байна! Энэ бол агуу их өөрчлөлтүүдийн дохио. Өнгөрсөн бүхэн түүх болж улирна. Энэ хот болоод түүний харьяа хязгааруудад олон зуун жил эзэн захирагчид эрх барьж байсан, би тэдний мөрөөр Минас-Тиритэд өөрийгөө өргөмжлөгч нэртэй орж, зөрчил сөргөлдөөн, буруу зөрүү ойлголт үүсгэхгүй. Үгүй ээ, би Мордортой хийж байгаа дайны эцсийг үзэлгүйгээр өөрийнхөө хот руу орохгүй. Миний асруудыг хаалганы ойролцоо босгоно биз, би хотын эзэн захирагчийн урилгыг хүлээнэ.

Гэтэл Эомер.

- Чи их хаадын тугийг мандуулсан, чи Эленделийн титэмтэй ирсэн! Тэгээд одоо эргэлзээ төрүүлэх гэж байна уу?

- Үгүй ээ, миний цаг хараахан бүрэлдээгүй байна, би Дайсны нүдэн дээр хэрүүл маргаан үүсгэмээргүй байна

Тэгтэл Имраиль ван.

- Мэргэн бодож байна, эзэн минь, би үүнийг чамд Денэтор удмын хүн болохоор хэлж байгаа юм. Тэр бол бардам зантай, дураараа авирладаг, хүү нь амь үрэгдсэнээс хойш санаа бодол нь будангуйрсан. Гэхдээ хаалганы дэргэд гуйлгачин шиг буух нь чамд зохимжгүй.

- Яагаад гуйлгачин шиг гэж? Би одоохондоо умардын мөрдөгч хэвээрээ байна, бид чулуун байшинд унтаж дасаагүй.

Тэгээд Арагорн тугаа эвхэж, очир эрдэнийн титмийг авахыг тушаагаад Элрондын хөвгүүдэд хадгалуулахаар өгөв. Имраиль, Эомер хоёр хот руу ороход шуугилдсан олон тэр хоёрыг хотын гудамжаар даган явж, цайзын хаалганд хүргэв. Тэр хоёр Цагаан цамхгийн хаан ширээний өргөөнд орж эзэн захирагчийг хүлээлээ. Гэвч түүний суудал хоосон, хаан ширээний хөлд Ристанийн эзэн захирагч Теоден алтан судалт туган дор нойрсч, эргэн тойронд нь зул асаалттай, Ристани, Гондорын арван хоёр ван зогсч байлаа. Түүний цээжин дээр нь нүцгэн илд, хөл дээр нь бамбай нь байна. Түүний өтгөн буурал үсэн дээр олон зулын гэрэл усан оргилуур дээр туссан нарны цацраг мэт тоглож, царай нь цэл залуу, гоо сайхан харагдах бөгөөд зүгээр л жаахан унтаад босох гэж байгаа юм шиг санагдана.

Тэд хэсэг дуугүй зогссоны дараа Имраиль асуув.

- Эзэн захирагч хаа байна? Митрандир хаа байна?

Хүндэт харуулуудын нэг нь.

- Гондорын эзэн захирагч Анагаах танхимд байгаа –гэж хариулахад нь Эомер.

- Миний эгч, хатан хаан Эовин хаа байна? Тэр эзэн захирагчтай хамт нойрсох ёстой, адил хүндэтгэл хүлээх ёстой. Хааш нь аваачсан бэ?

Тэгэхэд Имраиль.

- Тэнд, хотын хаалганы дэргэд хатан хаан Эовин амьд байсан. Чи мэдээгүй байсан юм уу?

Эомерын зүрхэнд найдварын оч гялсхийсэн боловч дэндүү түгшүүртэй байсан тул тэр нэг ч үг хэлэлгүй эргэж, Цагаан цамхгаас гарч явахад Имраиль дагаж явлаа. Харанхуй болж, тэнгэрт одод түглээ. Анагаах танхимын үүдэнд тэд Гэндальфтай тааралдав. Түүнтэй хамт нэг саарал цувгай хүн байлаа. Хоёр жанжин шидтэнд мэхийн ёслоод түүнд хандаж.

- Бид эзэн захирагчийг хайж явна. Энд байгаа гэж бидэнд хэлсэн юм. Тэр шархадсан юм уу? Бас хатан хаан Эовин хаан байгаа вэ?

Гэндалф шууд хариулав.

- Хатан хаан энд байна, тэр амьд, гэхдээ үхэлд ойрхон л байна. Фарамир хорт суманд шархадсаныг та хоёр мэдэж байгаа, тэр одоо Гондорын эзэн захирагч болсон, учир нь Денэтор амьд байхгүй, шарил нь үнс болсон.

Тэр хоёр ихэд гайхаж, гашуудлын энэ мэдээг сонсов. Тэгээд Имраиль.

- Энэ ялалт бидэнд баяр хөөр авчирсангүй. Гондор, Ристани хоёр эзэн захирагчаа алдсан болохоор их гашуун үнээр бид яллаа. Эомер мустангримчүүдийг захирна, харин Минас-Тиритийг хэн захирах юм бэ? Эзэн хаан Арагорн руу элч явуулах юм уу?

- Тэр хүрээд ирчихсэн – гэж цувтай хүн хэлэв. Тэгээд урагш гарч ирэхэд хаалганы дээрх дэнлүүний гэрэлд тэд Арагорныг танив, тэр хөө хуяган дээрээ лориэн цув өмсчээ. Түүнд титэм байгаагүй боловч Галадриэлийн бэлэглэсэн зүүлт энгэрт нь байлаа.

- Би энд Гэндалфын дуудлагаар ирсэн. Гэхдээ одоо би илүү ч үгүй, дутуу ч үгүй Арнорын дунаданчуудын удирдагч. Тиймээс Фарамирыг босох хүртэл хотыг Имраильд даалгаж байна. Тэгээд гол нь Гэндалфт итгэхийг түүнд зөвлөж байна. Энэ аймшигтай бэрх өдрүүдэд тэр бидний ерөнхий захирагч болно.

Бүгд зөвшөөрсөн тул Гэндалф.

- Хаалгын дэргэд зогсоод яахав, цаг биднийг хүлээхгүй. Явцгаая! Шархтнуудын хувьд Арагорнаас өөр найдах юм алга. Гондорын удган Иорета надад ингэж хэллээ. Эзэн хааны гарт эмчлэх хүч бий, жинхэнэ эзэн хааныг тэр хүчээр нь танина.

Арагорн түрүүлэн Анагаах өргөөнд оров. Хаалганы цаана цайзын хамгаалагчийн өмсгөлтэй хоёр харуул зогсч байв. Нэг нь өндөр чийрэг, нөгөө нь хүүхдээрээ амьтан байв. Тэр Арагорныг хараад босон харайж, баярлаж, гайхсандаа дуу алдан.

- Тэнэмэл! Ямар сайхан бэ! Тэр хар онгоцууд дээр чи л захирч яваа гэж би шууд ойлгосон, өөр хэн байдаг юм бэ! Бүгд л “Далайн дээрэмчид! Далайн дээрэмчид!” – гэж хашгиралдаад байсан? Чи яаж ингэж чадав аа?

Арагорн инээж, хоббитын гарыг бариад.

- Чамайг харж байгаадаа баяртай байна! Дараа ярья -гэв.

Имраиль Эомерт хандаж.

- Эзэн хаантай ингэж ярьж болдог юм уу? Ингэхэд ер нь хаан өөр нэртэй байвал яасан юм бэ! -гэхэд

Арагорн түүний үгийг сонсоод эргэн харж.

- Тийм ээ, өөр нэртэй байх болно, учир нь эртний хэлээр би Эльфийн Берилл Элессар, бас Энвинъятар гэж дуудагдана – гээд энгэр дээр нь гялалзаж байгаа ногоон зүүлт рүү хараад. - Гэхдээ би хааны гэр бүлийг үндэслэх тавилантай бол Тэнэмэл гэсэн нэр авсан ч яахав дээ. Эртний хэлээр энэ нэр тийм ч хачин сонсогдохгүй. Би Телконтар нэртэй болоод угсаа залгамжлагчиддаа энэ нэрээ өвлүүлнэ.

Тэд танхимуудаар орж, замдаа Гэндальф Эовин, Мериадок хоёрын гавьяаг ярьж өгөв. – Үхлийн өмнөх харанхуй тэднийг нөмрөхөөс өмнө би тэдний дээрээс олон цаг тонгойж, утга авцалдаагүй яриаг нь сонссон. Урьд нь ч би олон зүйлийг алсаас харсан л даа гэж тэр ярилаа. Арагорн эхлээд Фарамирыг, дараа нь Эовин, Мерри хоёрыг үзэв. Тэднийг сайтар үзээд, цусгүй нүүрнүүдийг харж байгаад хүндээр санаа алдлаа.

- Би тус болж чадах уу, үгүй юу, надад тийм их хүч байна уу, үгүй юу гэдгийг би мэдэхгүй байна. Гэхдээ чадах бүхнээ хийнэ ээ. Элрондыг аваад ирж болдог болоосой, дунаданчуудын хамгийн ахмад, агуу анагаагч юм шүү дээ.

Тэр хичнээн ядарсан, арга нь барагдсан байртай байхыг хараад Эомер.

- Чи эхлээд жаахан амарч, хүчээ сэлбэх юм уу?

Гэвч Арагорн.

- Үгүй ээ, энэ гурвын хувьд цаг дуусч байна. Фарамирынх бараг л дууссан шиг байна. Алгуурлаж яасан ч болохгүй. Тэгээд Иоретэд хандаж.

- Энд нөөцөлсөн эм, эмийн ургамал байна уу?

- Байлгүй яах вэ, эрхэм дээдэс ээ, - гэж тэр хариулаад. - Гэхдээ бага л үлдсэн дээ, энэ олон шархтанд өгөхөөс өөр яахав. Тэгээд ч одоо хаанаас авах вэ дээ, эргэн тойронд харанхуй, утаа, гал түймэр, хоёр ч удаа хүн явуулаад бүтээгүй, бүх зам хаалттай юм чинь хаашаа явах ч юм билээ! Лоссарнахаас сүүлчийн ачаа хэзээ ирснийг ч санахгүй байна. Байгаа бүхнээ үзүүлье, өөрөө хар даа, эрхэм дээдэс минь.

- Үзье дээ, бидэнд хамгийн их дутагдаж байгаа зүйл бол ярилцах цаг байна, Анагуур байгаа юу?

- Байж магадгүй эзэн минь, би мэдэхгүй байна, нэрийг нь ч сонсоогүй юм байна. Би өвс судлаачаа дуудаадахья, тэр эртний бүх ургамлын нэрийг мэднэ.

- Гондорт түүнийг энгийн хэлээр хатан цэцэг гэдэг шиг санагдаж байна. Тэгээд байгаа юм уу?

- Аа, та тэрнийг хэлсэн юм уу! Тэгээд л хэлчихгүй дээ. Тэгсэн бол би шууд хариулахгүй юу. Үгүй ээ, тийм ургамал манайд байхгүй, би бүр сайн мэдэж байна. Та юу ярина вэ, тэгээд ч тэр өвсөнд чинь ямар ч анагаах чадал байхгүй, өвс шиг л өвс, навч нь л нэлээн том байх. Би

эгч дүү нартайгаа ойд тэр цэцгэн дээгүүр туучиж явдаг байлаа, тэгээд би хэлж байсан юм. “Хатан цэцэг гэнэ шүү, мөн нэр өгөв өө, яагаад тэгж нэрлэсэн юм бол, ойлгохгүй байна, би хатан хаан байсан бол миний цэцэрлэгт энэ байтугай л цэцэг ургана!” гэж байсан юм. Өндгөн дээрээ няцлахаар сэнгэнэсэн үнэр гардаг юм, сэнгэнэсэн ч гэж дээ нэг тийм амьдуурлагч гэмээр үнэр гараад байдаг юм.

- Тэгээд яагаа вэ, амьдруулагч- гэж Арагорн хэлээд – Хэрэв та эзэн захирагч Фарамиртаа үнэнээсээ хайртай юм бол илүү юм ярилгүй дайснууд хотын дээгүүр яаж хурдан нисч байгаа шиг бүх хотыг нэгжээд, надад хатан цэцэг авчирч өг, ганц навч ч байсан авчирч өг.

Гэндальф

- Хотод байхгүй бол би Лоссарнах руу Иоретаг дагуулж явахаас. Эгч дүү нарыг нь эргэхгүй, харин хатан цэцгийг авчирна. Аянгын нуруун дээр гараад “хурдан” гэж юу байдгийг мэдэх болно.

Иорета явж, Арагорн эмэгтэйчүүдэд ус буцалгахыг даалгав. Дараа нь Фарамирын гараас барьж, хүйтэн хөлс нь урссан духыг нь илэв. Фарамир огт хөдөлгөөнгүй, бараг амьсгаагүй байлаа.

- Явж байна, - гээд Арагорн, Гэндальф руу эргэж. - Шархандаа ч гай нь байгаа юм биш. Харахгүй юу, шарх нь аньж байна. Хэрэв түүнд хар үхээрийн сум туссан бол өнгөрсөн шөнө үхэх байсан. Тэгэхлээр хородримийн сум юм шиг байна. Хэн тэрнийг сугалж авсан бэ? Хадгалсан уу?

- Би сугалсан – гэж Имраиль хариулаад, - Шархыг нь ч би боосон. Сумыг шидчихсэн, хадгалах бодол толгойд орж ирээ ч үгүй, тэрэнтэй манатай юм болж байсан юм чинь. Харин одоо санаж байна. Ердийн л нэг хородримийн сум байсан. Дээрээс нь харвасан юм байна гэж би бодсон, тэгээгүйсэн бол Фарамир тэгэж тамир алдахгүй байсан. Шарх нь гүн биш. Чинийхээр бол учир нь юундаа байна?

- Үхтлээ ядарсан байсан, эцгээс нь болоод санаа сэтгэл нь их хямарсан байсан. Дээр нь шархадсан, гол нь хар үхлийн өвчин, - гэж Арагорн хэлээд – Тэр аймшигт өвчинтэй хатан зоригоороо тэмцэж байсан, тэр өвчний үхлийн аюул саяны тулалдаанаас хамаагүй өмнө түүнийг нөмөрсөн байжээ. Тэгээд сүүлчийн хүчээ шавхан тулалдаж байхад нь өвчин дийлжээ. Би хожимдсон юм шиг байна!

Тэгтэл ч өвс судлаач ороод ирэв.

- Эрхэм дээдэс та ардуудын дунд хатан цэцэг гэж нэрлэдэг, өөрөөр хэлбэл ацэлас, валинор хэлээр анагуур гэдэг... Арагорн түүний үгийг таслаад.

- Би түүнийг асуусан юм хаана, ацеа аранион, хатан цэцэг гэж нэрлэдэг нь надад хамаагүй, тэр танайд байна уу?

- Эрхэм дээдэс та зөвшөөрвөл! – гэж тэр хэлээд – Ивээлт эзэн та зөвхөн баатар дайчин

төдийгүй эртний домгуудыг мэддэг тань харагдаж байна. Гэвч эрхэм дээдэс та болгоовол анагаах танхимд тэр өвс байхгүй, бид энд хүнд өвчтэй болон хүнд шархтнуудыг л эмчилдэг шүү дээ. Тэр өвс бол онцгой анагаах хүч байхгүй, зөвхөн агаарыг цэвэрлэж, хөнгөн тансаг үнэр гаргадаг юм, за яахав бага зэрэг сэргээх үйлчилгээтэй. Тэр ургамлын тухай эртний нэг шүлгээр ойлгож хэрэггүй, тэр шүлгийг манай буянт Иорета санаж байж ч магадгүй.

Үд дундуур даараад эхэлбэл,

Үхэл сүүдэр шиг дагаад ирвэл,

Эцсийн аврал анагуурт буй,

Эзэн хааны гараар өгвөл

Эрхбиш эдгэх нигуур буй

Энэ шүлэгт сохор зоосны ч утга агуулга байхгүй гэдгийг эрхэм дээдэс та өөрөө харж байна, зөнөсөн удганы толгойд юу эс байдаг билээ. Гэхдээ хуучны уламжлалаар анагуурын хандаар толгойн өвчин намдаах тал ч бий.

- Эзэн хааны нэрээр андгайлъя, - хэмээн Гэндалф дуу алдаж. - Нэн даруй айлуудаар хэс. Магадгүй ийм их мэргэн ухаангүй ямар нэг хөгшнийд байж магадгүй! – гэж тушаав.

Арагорн Фарамирын лоожны өмнө сууж, алгаа духан дээр нь тавилаа. Тэр танхимд байсан бүх хүн хүнд хүчир их тэмцлийн гэрч болов. Арагорны царай ядарсандаа сааралтаж, байн байн Фарамирыг дуудаж байсан бөгөөд түүний дуудлага улам улам бүдгэрч, тэр ямар нэг зэлүүд харанхуй хөндийгөөр төөрсөн нэгнийг эрж яваа юм шиг хаа холоос дуудаж байх шиг.

Бергил даавуунд боосон зургаан урт навч барьсаар гүйн орж ирэв.

- Энэ байна эзэн минь, хатан цэцэг, - гэж амьсгаадан хэлээд – харин шинэ биш, хоёр долоо хоногийн өмнө түүсэн юм, хэрэг болох болов уу? - гээд Фарамир руу харснаа асгартал уйлав.

- Хэрэг болно оо – гэж Арагорн түүнд инээмсэглэн хэлэв – Хамгийн аюултайг нь давчих шиг боллоо. Танхимд үлдээд жаахан амарч ав! – гэв.

Тэрбээр хоёр урт навч аваад амандаа ойртуулан үлээж, алгандаа үйрүүлэхэд танхимд амьдруулагч үнэр сэнгэнэж, агаар оч татуулан сэвэлзэх шиг болов. Дараа нь тэр буцалсан устай аяганд навчаа хийхэд хүн бүхний сэтгэл сэргэж, зөвхөн мартагдсан дурсамж л дөнгөн данган санагдах тэр цэнхэр хязгаарын шүүдэрлэг өглөө үнэртэх шиг боллоо. Арагорн хөнгөн шингэн ухасхийн босч, нүдээрээ инээмсэглэн аягатай эмээ Фарамирын цонхигор нүүрэнд ойртуулав.

- Мөн хачин аа! Ингэнэ гэж хэн санах вэ дээ? – гэж Иорета сахиул эмэгтэйд хэлээд – Зүгээр нэг өвс байш байх нь хөөе. Би Имлот-Мелуиг саначихлаа байна. Би тэнд өссөн юм, тэндхийн сарнайгаар эзэн хааныг чимсэн ч болно.

Фарамир гэнэт хөдөлж, нүдээ нээгээд, дээрээс нь тонгойсон Арагорныг хараад таньж, харц нь баяртай гийгээд аяархан шивнэв.

- Эзэнтэн, та намайг харанхуйгаас дуудаж авчирлаа. Зарлигдаарай – би захирагдана.

- Ухаан орж сэр, харанхуйд бүү төөр! Ядаргаагаа дав, амар, хүч тамираа сэргээ, тэгээд намайг ирэхийг хүлээ - гэж Арагорн тушаав.

- Зарлиг бүрийг чинь биелүүлнэ, Эзэн хаан маань Гондорт эргэж ирлээ, ирээд хар үхлийн өвчнийг дарлаа - гэж Фарамир хэлэв.

- За баяртай! Би бусад шархтан руу явлаа – гэж Арагорн хэлээд Имраиль, Гэндалф хоёртой танхимаас гарч, Берегонд хүүтэйгээ Фарамирын дэргэд үлдэв. Аав, хүү хоёр аз жаргалдаа умбаж байгаа харагдана. Пин Гэндалфын хойноос явахаар гарахдаа Иоретын хэлэхийг сонсов.

- Эзэнтээн! Та сонсохгүй байна уу? Би юу гэсэн билээ? Би “Эзэн хааны гарт эмчлэх хүч бий” гэж хэлээ биз дээ.

Удалгүй хотоор Минас-Тиритэд эзэн хаан ирсэн, тэр дайчин баатар төдийгүй бас анагаагч шидтэн гэсэн яриа тарлаа.

Эовиний дэргэд ирээд Арагорн.

- Аймшигтай хүчээр цохиж, их хүнд гэмтээсэн байна. Гэхдээ хугарсан гарыг гарамгай сайн боосон байна, гар нь эдгэрнэ. Амьдрах хүч ч хүрэлцэнэ. Зүүн гар нь хугарсан ч аюулгүй, харин илд барьж байсан баруун гар нь үхлийн аюултай. Гар нь бүтнээрээ боловч үхжсэн байна.

Хатан хаанд хүнд хувь тохиожээ. Тийм хүчирхэг, аймшигт дайсантай тулалдахад гангаас хатуу байх хэрэгтэй, тэгэхгүй бол хэрээс хэтэрсэн их чармайлт өөрийг чинь хөнөөнө. Хатан хаан үхлийн халз тулаан хийсэн. Тэр бол хаадын удмын чимэг, гайхамшигтай эмэгтэй. Тэр өөрийнхөө хэрээс хэтэрсэн сорилт хайж байх шиг надад санагдсан. Би анх түүнийг хараад алмайран биширсэн. Тэр лишь цэцэг шиг уран гоо, бардам, тэгэхдээ, эмзэгхэн биш, эльфийн урчууд гангаар давтсан юм шиг харагдсан. Эсвэл мөстсөн цэцэг шиг дур булаам үзэсгэлэн төгс мөртөө уйтгар гуниг дүүрэн. Тэр аль эртнээс гунигт идэгдэж байсан, тийм үү Эомер?

- Би гайхаж байна, эзэнтээн, яагаад надаас асууж байгаа юм бол гэж. Би чамайг буруутгаагүй байна, энд чи ямар ч өө сэвгүй, гэхдээ миний эгч Эовин чамайг харах хүртлээ хэзээ ч мөстсөн цэцэг шиг байгаагүй. Өмхий Амт эзэн захирагч байсан тэр золгүй цагт бид хоёр түгшүүр, зовлон бүхээ хуваалцдаг байсан. Мэдээж түүнд зовлонтой л байсан. Гэхдээ гуниг түүнийг идээгүй ээ!

- Найз минь, - гэж Гэндалф түүнд хэлээд, - Чи хайртай морио унаад ристанийн талуудыг хэсч, дайснуудтай тулалддаг байсан, харин Эовин эмэгтэй болж төрсөн боловч эр зоригоор ч, сэтгэлийн хатаар ч чамаас дутуугүй. Тийм атлаа эцэг шигээ хайрладаг өвгөнийг асарч тойглох

хувьтай байсан, тэрний ухаан нь яаж доош орж байгааг ч харж байсан.

Өмхий Амт Теоденыг зөвхөн хэл амаар хордуулдаг байсан гэж чи бодож байна уу? “Ухаан муут хүний оронцог! Чиний Эорлын өргөө чинь согтуу алуурчингууд бөөлжсөн дээрээ хөндлөн гулдгүй хурхиралдаж байдаг өтөгний амбаар, тэдний бөөст орхидосууд золбин нохойнуудын дунд мөлхөж явдаг гэхчлэн!” ийм үгнүүдийг санаж байна уу? Тэдгээрийг Өмхий Амтын багш Саруман хэлсэн юм. Харин Өмхий Амт арай зальтай, арай бодолтой юм хэлдэг байсан. Харин чиний эгч чамд хайртай учраас, хүлээсэн үүрэгтээ үнэнч учраас дуугардаггүй байсан юм, тиймгүйсэн бол түүний амнаас тун ч хатуу үг гарах л байсан. Гэвч тэр ганцаараа, гүн шөнөөр ганцаараа сууж байхдаа, амьдралаа өөрөө сүйтгэсэн юм шиг санагдаж байхдаа, суудаг ордон нь алтан тор шиг юм уу шорон шиг санагдаж байхад ямар үг шивнэж байсныг хэн мэдэх билээ?

Эомер дуугарсангүй, эгч рүүгээ харж, өнгөрсөн он жилүүдийг дотроо бодож байлаа. Арагорн түүнд хэлэв.

- Би чиний юун тухай ярьж байгааг мэдэж байна аа, Эомер. Надад итгээрэй, надаас болоод хариу хайргүй үлдэх болсон хайрыг харах ямар гунигтай, шаналгаатай байдаг гээч. Би гунигт унасан хатан хааныг Дунхергт орхиод, үхдлүүдийн замд дээр гарахад Зүрхийг минь гуниг мэрж байсан. Тэр аймшигт замд хамгийн аймшигтай юм бол миний хувьд түүний тухай бодох байсан. Гэлээ ч гэсэн чамд хэлэхэд, Эомер, тэр чамд жинхэнээсээ хайртай, чамайг мэддэг, хайрладаг, харин би бол ердөө л түүнд алдар нэр, баатарлаг гавьяа, алсын аяны тухай мөрөөдөл төрүүлж өгсөн.

Магадгүй, би түүнийг харанхуйн хөндийгөөс буцаан авчирч чадах байх. Гэвч энд түүнийг юу хүлээж байна вэ? Итгэл найдвар уу? Зовлон гуниг, цөхрөл үү, би мэдэхгүй. Хэрэв түүнийг цөхрөл хүлээж байгаа бол тэр үхнэ, би аварч чадахгүй. Тэр алдар гавьяаныхаа эзэн болчихоод үхнэ гэж үү!

Арагорн бөхийж, түүний нүүр рүү харав. Хатан хааны царай цаснаас цагаан, мөснөөс хүйтэн, чулуун хөшөөнөөс хатуу харагдаж байлаа.. Гэвч Арагорн түүний духан дээр үнсээд, аяарханаар ийн хэлэв.

- Эомундын охин Эовин, сэрээрэй! Чиний дайсан сөнөсөн!

Хатан хаан эхлээд хөдөлсөнгүй, гэвч дараа нь жигдхэн, гүн амьсгаалж, цагаан бүтээлгэн дорх цээж нь өндийж ирэв. Арагорн дахин хоёр навч анагуур имэрч нунтаглаад, буцалсан усанд хийж, Эовиний магнай, амьгүй хөшсөн баруун гарыг нь норгов.

Арагорн эртний өрнөдийн мартагдсан ид шидийг эзэмшсэн юм уу, Хатан хаан Эовины тухай сонсогдохооргүй хэлсэн үг гайхамшигт цэцгийн хандтай нууцлагаар найрссан юм уу, бүү мэд, гэнэт цонхоор тансаг үнэрт салхи сэнгэнэх шиг болж, тэрхүү сэнгэнэсэн хөөст давалгаанд угаагдсан алсын мөнгөлөг эргээс, оддын дорх мөнх цаст оргилуудаас салхи хөлөглөн ирэх шиг тийм цэвэр онгон байлаа.

- Сэрээрэй, Эовин, Ристанийн хатан хаан минь! – гэж Арагорн хэлээд үл мэдэг бүлээссэн

баруун гарыг нь барьж.

- Сэрээрэй! Үхдэл сүгнүүд алга болж, балар харанхуй утаа шиг хийсэн алга боллоо – гээд түүний гарыг Эомерт бариулж - Дуудаарай! – гээд гарлаа.

- Эовин, Эовин! - хэмээн Эомер нулимсаа залгин дуудав. Эовин нүдээ нээгээд.

- Эомер! Ямар сайхан юм бэ! Чамайг алагдсан гэж надад хэлсэн. Үгүй үгүй, нойрон дунд хорон санаатны дуу хоолой тэгж шивнээд байсан. Би удаан унтсан уу?

- Үгүй ээ, эгч минь, чи удаан унтаагүй, энэ тухай дахиж битгий бод!

- Яагаад ч юм би аймшигтай их ядарчээ. Би жаахан амрах хэрэгтэй байна. Нэг л юм хэлчих. Эзэн захирагч хаана байна? Үгүй, хэрэггүй! Би мэдэж байна, энэ бол зүүд биш. Тэр үхсэн, тэр үхлээ урьдаас харсан.

- Тийм ээ, тэр үхсэн, түүний сүүлчийн үг чиний нэр байсан, яагаад гэвэл тэр чамд охиноосоо илүү хайртай байсан. Тэр одоо агуу хүндэтгэл дунд, Гондорын эзний цайзад нойрсч байна.

- Үүнийг сонсоход надад гунигтай байна, гунигтай ч гэсэн баяртай байна. Эорлын өргөө ядуу амбаар шиг хөөрхийлөлтэй байсан тэр хар өдрүүдэд би манай өргөө дахин сэргэн мандана гэж найдах зоригтой байсан уу? Эзэн захирагчийн зэвсэгч нөгөө жижиг биет яасан бол? Эомер, тэр Ристанийн ван болох гавьяатай шүү!

- Тэр энд, хажуугийн өрөөнд байгаа, одоо би тийшээ орно - гэж Гэндальф хэлээд. - Эомер чамтай хамт жаахан байг, гэхдээ дайн, танай гай зовлонгийн талаар бүү яриарай. Чи эхлээд тэнхрэх хэрэгтэй. Чиний хүч чадал, итгэл найдвартайгаа хурдан сэргэх болтугай!

- Хүч чадал уу? Тэр ч сэргэж ирэх байх аа, алагдсан дайчны эмээлтэй морь надад олдоно. Дайн дуусаагүй байгаа шүү дээ. Харин итгэлд найдвар? Би юунд найдах юм бэ? – гэж Эовин хэлэв.

Гэндальф, Пин хоёр Меррийн хэвтэж байгаа өрөөнд ороход Арагорн дэргэд нь зогсч байв.

- Мерри, хөөрхий минь! - гэж Пин хашгираад найз руугаа ухасхийв. Цаадах нь урьдахаасаа ч муудаж, саарал царай нь шөвийж, хөгширсөн юм шиг харагдав. Үхчих юм биш байгаа гэж Пин айлаа.

- Бүү ай - гэж Арагорн түүнийг тайвшруулав. - Би түүнийг харанхуйгаас амжиж дуудаж чадлаа. Тэр их ядарсан, уй гашууд дарагдсан, хатан хаан Эовины адил үхэл тээгч рүү зэвсэг далайсан. Одоохон сэргэнэ. Тэр бол гуньж гутахыг мэддэггүй, сэтгэлийн хат ихтэй. Уй гашуу нь мартагдахгүй, гэхдээ түүнийг улам ухаантай болгоно.

Тэгээд Арагорн духан дээр нь гараа тавьж, өтгөн хүрэн үсийг нь илээд, хөмсөгийг нь сөхөж нэрээр нь дуудав. Өрөөнд анагуурын амьдруулагч үнэр сэнгэнэхэд жимсний цэцэрлэгт нарлаг өдөр зөгий дүнгэнэлдэх шиг болоод Мерри гэнэт сэргэв.

- Ямар их өлсч байна аа. Хэдэн цаг болж байна? – гэж асуулаа.

- Оройн хоол идэх арай л оройтсон, гэхдээ би гарч гүйхэд чамд идэх юм олоод ирнэ ээ, хүмүүс өгнө - гэж Пин харулав.

- Өгнө, өгнө - гэж Гэндалф батлаад – Ристанийн энэ дайчин юу л хүснэ, Минас-Тиритийг эргүүлж байгаад ч хамаагүй авчирч өгнө. Тэр одоо энд их хүндтэй хүн болсон – гэв.

- За ашгүйдээ! Сайхан идэж ууж аваад дараа нь нэг сайхан тамхилна аа – гэснээ царай нь эвгүй болж. - Тамхи татахаа больё. Ер нь цаашдаа тамхи татахгүй - гэв.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? - хэмээн Пин сониучирхав.

- Чамд юу гэж тайлбарламаар юм бэ дээ, - гэж Мерри үгээ зөөн өгүүлээд – Тэр үхчихсэн, тэгээд л болоо. Би сая бүгдийг тод саналаа. Тэр үхэхийнхээ өмнөхөн надад өвс ургамлын тухай яриаг чинь сонсч чадахгүйдээ харамсч байна гэж хэлсэн юм. Би одоо тамхи татах юм бол түүнийг бодож эхэлнэ, Пин, чи санаж байна уу, Изенгардын хаалганд дөхөж ирээд яаж бидэнд санаа тавьж байсныг?

- Яахав дээ, тамхиа сороод л түүний тухай бодож байхгүй юу! – гэж Арагорн өгүүлэв. - Түүний сайхан сэтгэл, өгөөмөр зангийн тухай бод, агуу дайчин байсныг нь бод, тэр нөхөрлөлийн тангарагтаа үнэнч байж, сүүлчийнхээ өглөө ристанийн цэргийг харанхуй дундаас тунгалаг өглөөний өөдөөс удирдан тулалдсаныг нь бод. Чи түүнд богино хугацаагаар зүтгэсэн ч гэсэн түүний тухай дурсамж чиний бүх насны чинь амьдралыг сүүлчийн өдөр чинь хүртэл гийгүүлэх болно.

Мерри инээмсэглэлээ.

- За яахав, - Тэнэмэл минь, өвс гаанс хоёроо өгчих. Би тамхиа соронгоо бодъё. Миний үүргэвчинд Саруманы нөөцнөөс авсан онцгой сайн тамхи байсан, тулалдааны үеэр тэр үүргэвч хаачсаныг чөтгөр л мэдэх байх.

- Эрхэм ноён Мериадок минь, хэрэв чи намайг байлдааны хэрэгслээ тулалдааны талбарт хаясан доожоогүй муу цэрэгт татах тамхийг нь өгөхийн тулд олон уул давж, гондорын вант улсын нутгийг бүтэн туулан, илдний хурц, галын хүчээр замаа цэвэрлэж энд ирсэн гэж бодож байгаа бол эндүүрэл болно. Тамхины хүүдийгээ гэсэн бол эндхийн өвс судлаачийг дууд. Тэр чамд гэнэт хэрэг болсон тэр өвс ямар ч ашиггүй гэдгийг тайлбарлаж өгнө, бас түүний мэдэж буйгаар бол тэр өвсийг ардын ярианы хэлээр зүгээр л өрнөдийн өвс гэдэг, эрдмийн хэлээр галенас гэдэг, мөн өөр арваад хэлээр юу гэж нэрлэдгийг хэлж өгнө, дараа нь хагас мартагдсан эртний зарим нэг шүлэгнээс уншиж өгнө, тэгээд тэр шүлэг ямар ч утга агуулгагүй гэдгийг нотолно. Эцэст нь тэр өвс анагаах тахимд огт байхгүй гэдгийг гүнээ харамсалтайгаар мэдэгдэнэ. Тэгээд чи Дундад газрын эртний хэлнүүдийн тухай бодоод хоцорно. Одоо би явлаа, чи бодож сэтгэ. Би Дунхергээс гарснаасаа хойш оронд орж унтаагүй, өчигдөр оройноос хойш хэлэн дээрээ юм тавиагүй яваа.

Мерри Арагорны гарыг шүүрэн авч үнсэв.

- Намайг уучлаарай, хурдхан явж унт! Бид нар бүр Уулын суурингаас эхэлж чиний толгой дээр зайдалсан. Гэвч, манай хоббитууд ноцтой хэрэг гарвал боломжийг алдчихгүйн тулд зориуд дэмий балай юм ярьж эхэлдэг. Шоглохтой манатай юм болоход бидэнд хэлэх үг олддоггүй юм.

- Сайн байна. Би үүнийг сайн мэднэ, мэддэггүй байсан бол чамтай огт өөр хэлээр ярина шүү дээ. За баяртай, Хоббитан орон үеийн үед мандтугай! – гээд Арагорн Мерриг үнсээд гарахад Гэндальф даган гарав.

Пин өрөөнд үлдэв.

- Ийм хүнийг ч ертөнц даяар хайгаад олохгүй дээ! Мэдээж Гэндальф байгаа л дээ. Энэ хоёр лав ах дүүс байх шүү – гэж тэр Меррид хэлснээ дух руугаа алгадаад – Өө, мал мал аа, үүргэвч чинь тэр байна шүү дээ, чи үүрээд л ирсэн байна. Даан ч тэр сая тамхины тухай ярихад тийшээ хараад байсан юм аа. Надад ч хоёр хүнд хангалттай хүрэх тамхи бий. Май, үүргэвч ухаад яахав. Урт сүүлтээс авч гарсан нөгөө тамхинаас үлдсэн юм. Сорж бай, би хоолонд явлаа. Орж ирээд хоббит маягаараа сайхан хөөрөлдье. Ёох! Бид ч ийм өндөрт амьдарч дасахгүй юм байна даа. Хамаг юм нь хамаагүй өндөр байх юм.

- Тэр ч тийм шүү, мэдээж дасахад хэцүү, гэхдээ яаж ийгээд тэсч болно. Харин би нэг юм ойлголоо, Пин. Ийм өндрүүд байдгийг бид одоо мэддэг болсон, энэ өндрүүд рүү олийгоод харж байна. Бурхнаас заяасан юмандаа хайртай байх гэдэг мэдээж сайхан, бүх юм нэг юмнаас эхэлдэг, түүн дээрээ суурилах ёстой, азаар манай Хоббитанийн газар үржил шим ихтэй. Гэвч амьдралд өндөр, гүн гэсэн хоёр юм байна. Ямар нэг өвгөн цэцэрлэгч үүнийг огт мэдэхгүй боловч түүнийг тэнгэр бурхан болоод ивээж байгаа учраас, тэнгэрийн таалалд нийцэж байгаа учраас л цэцэрлэгч хийж байгаа юм. Би үүнийг бага ч гэсэн ойлгосондоо баяртай байна. Нэг юм ойлгосонгүй, би юу яриад эхлэх нь энэ вэ? Чиний өвс чинь хаана байна? Юу ч гэсэн миний үүргэвчнээс гаанс гаргаа өг, бүтэн байх ч юм билүү.

Арагорн, Гэндальф хоёр Анагаах танхимын эрхлэгч дээр орж, Эовин, Фарамир хоёрыг ямар ч шалтгаанаар хэд хоногтоо гадагш гаргахгүй байх, тэр хоёрыг нүд салгалгүй ажиглаж байхыг даалгав.

- Хатан хаан Эовин байлдаанд хурдхан мордохыг хүсч байгаа юм. Ямар ч гэсэн түүнийг ядаж арав хоног гаргалгүй тогтоох хэрэгтэй - гэж Арагорн хэлэв.

- Фарамирын тухайд, эцэг нь үхсэнийг тэр өнөө маргаашгүй мэднэ. Гэвч Денэторын солиорсон тухай тэр бүрэн эдгэрч, ямар ч завгүй болох хүртлээ мэдэх ёсгүй шүү. Берегонд болон жижиг харуулд би хэлээ хавчиж бай гэж захиана, гэхдээ л тэднийг харж хянаж байх хэрэгтэй – гэж Гэндальф хэллээ.

- Жижиг Мериадок шархадсан шүү дээ, түүний талаар даалгавар байна уу? – гэж эрхлэгч асуулаа.

- Тэр маргааш босоод ирнэ дээ, за яахав, найзуудтайгаа бага зэрэг зугаалж байна биз - гэж Арагорн хэлэв.

- Сонин ардууд шүү - хэмээн эрхлэгч ойлгосон байртай толгой дохиод – Мөн ч бөх эрчүүд юм даа! – гэв.

Танхимын үүдэнд Арагорныг харахаар ирсэн хүмүүс бөөгнөрчээ. Тэд тэр хоёрын араас хөвөрсөөр. Оройн хоолоо идээд гарч ирэхэд шархадсан, бэртсэн, хар үхлийн өвчинд нэрвэгдсэн хүмүүсийг эмчилж өгөхийг гуйцгаалаа. Арагорн Элрондын хөвгүүдийг дуудуулж, тэр гурав шөнө дунд болтол эмчилгээ хийв. ”Жинхэнэ эзэн хаан хүрээд ирсэн байна” гэсэн яриа хотоор нэг тарлаа. Түүний энгэрт ногоон туяат эрдэнийн чулуун зүүлт гялалзаж байх учир Эльфийн Берилл хэмээж байв. Ийнхүү түүнийг энэ ертөнцөд төрөхөд зөгнөж хэлсэн нэрийг ард түмэн өөрөө сонгож өгчээ.

Туйлдаа хүртэл ядарсан тэрбээр шөнө дунд юүдэнт цуваа битүүлэн өмсч, нууцаар хотоос гараад үүрээс өмнөхөн асартаа очиж унтав. Өглөө нь Цагаан цамхгийн орой дээр Дол-Амротын хун цагаан хөлөгтэй цэнхэр далбаа намирч байхыг хараад хүмүүс жинхэнэ эзэн хаан эргэж ирсэн нь зүүд байсан юм болов уу гэж боджээ.

Бүлэг 9

Сүүлчийн зөвлөл дээр

Маргааш өглөө нь цэлмэг тэнгэрт сэмжин цагаан үүл нүүж, баруунаас сэвэлзүүр салхитай байлаа. Леголас, Гимли хоёр эртлэн босч, Мерри, Пин хоёртой уулзахаар явав..

- Амьд яваад нь баярлаж байна. Гэлээ ч гэсэн гомдолтой л байна. Эд нарын ачаар бид мөн ч их тэнэлээ дээ! –хэмээн Гимли үглэж явлаа.

Эльф, гном хоёр баатар гар гараасаа хөтлөлцөн Минас-Тирит рүү ороход тааралдсан хүмүүс үзээгүйгээ үзсэн мэт гайхаж байв. Үлэмж гоо царайтай, хөвөх мэт хөнгөн алхаатай Леголас эльфийн өглөөний дууг цангинуулан дуулж, Гимли хууз сахлаа илэн, эргэн тойрноо сонжин харсаар их л ихэмсэг алхана.

- Энэ барилгын ханыг сайн өрсөн байна, чулуу нь ч сайн юм, харин тэр барилга ямарч хэрэг алга, гудамж нь ямар ч замбараа алга хэмээн Гимли байшин барилгыг шүүмжилж явав. Арагорныг хаан ширээндээ залрахаар манай уулын чулуучдыг нааш нь илгээнэ ээ, манай уран барилгачид энэ хотыг харах нүдний чимэг болгоно – гэж тэр хэлэхэд.

- Цэцэрлэг алга, юу гэсэн үг вэ. Нүцгэн хад чулуунаас өөр юу ч үгүй, амьд зүлэг ногоо бараг алга. Арагорн хаан ширээнд суудаг юм бол манай ойн эльфүүд энд мөнх ногоон модод тарьж, дуучин шувууд үржүүлнэ – гэж Леголас өгүүллээ.

Тэр хоёр Имраиль вангийн өргөөнд ороход Леголас түүнийг харангуугаа гүнээ мэхийн ёсолсон нь ван эльфийн удам болохыг таньсан хэрэг ажээ.

- Амрыг эрье, ноёнтон! Нимродэль аль дивангарт Лориэний ойг орхисон боловч түүнтэй хамт байсан бүхэн бүгдээрээ Амротийн боомтоос баруун зүг хөвж одоогүй гэдгийг би харж байна – гэж тэр өгүүлэв.

- Тийм ээ, хэрэв манай домгууд үнэн бол олон нь үлдсэн – гэж ван хариулаад – Гэвч балар эрт үеэс манай гайхамшигт садангууд наашаа ирж байгаагүй. Би нүдэндээ ч итгэхгүй байна. Энэ их дайн тулаан, гай гамшгийн цагт Минас-Тиритэд эльф явж байдаг! Ямар салхи чамайг тууж ирээв?

- Би Имладрисаас Митрандиртай хамт гарсан тэр есийн нэг нь байна аа, энэ бол миний найз гном, бид хоёр эзэн хаан Арагорнтай хамт хөвж ирсэн юм. Бид хоёр манай найз бөгөөд хамтран аялагч Мериадок, Перегрин хоёртой уулзах гэж явна. Тэд таны асрамжинд байгаа гэж сонсоод ирлээ.

- Тийм ээ, та хоёр тэднийг Анагаах танхимд олно, би та хоёрыг хүргээд өгье – гэж Имраиль хэлэв.

- Бид хоёрт замчин гаргаж өгсөн нь дээр байх аа, ноёнтоон - гэж Леголас хэлээд – Учир нь

Арагорн өнөөдөр хотод орж ирмээргүй байна, гэхдээ цэргийн зөвлөл яаралтай хуралдах хэрэгтэй байна гэж танд дамжуулаарай гэсэн юм, тэгээд таныг Ристанийн Эомерын хамт асартаа ирэхийг урьсан, Митрандир тэнд оччихсон байгаа.

- Бид даруй очно – гэж Имраиль хэлэхэд мань хоёр мэхийн ёслол.

- Агуу ван, эрэлхэг жанжин байна - гэж Леголас гном нөхөртөө хэлээд – одоо, гандаж буурсан цагт нь Гондорт ийм захирагчид байгаа юм чинь мандан бадарч байх цагтаа Гондор ямар байсан бол!

- Тийм ээ, хуучны барилга бат бөх, найдвартай байдаг, хүмүүсийн ажил амьдрал ч тийм. Хавар нь хүйтэн саад болдог, зун нь ган гай болдог, тэгээд амласан нь хэзээ ч биелдэггүй.

- Гэхдээ санаанд ороогүй байтал их ургац хураадаг шүү дээ. Энд хэзээ ч, юу ч ургахгүй гэж бодож байсан үнс, тоосон дундаас гэнэт шинэ ургамал ургадаг. Үгүй ээ, Гимли, хүмүүсийн бүтээл биднийхээс урт настай.

- Гэвч хүмүүсийн мөрөөдөл бүтэлгүй.

- Үүнд эльфүүд хариу өгч чаддаггүй.

Вангийн зарлага тэр хоёрыг анагаах танхимд хүргэж өгөхөд андууд нь цэцэрлэгт сууж байсан бөгөөд энэ уулзалт жинхэнэ баярт уулзалт байлаа. Тэд өглөөний тайван агаарт цэцэрлэг дундуур алхангаа ханатлаа хөөрөлдөв. Сүүлдээ Мерри ядарч, тэд төглийн хажуугийн хэрэм дээр тухаллаа. Өргөн их Андуин наранд гялалзан, намуухан давалгаат их усаа өмнө зүг рүү урсган нүдний хараанаас алдарна. Лебеннин, өмнөд Итилийн ногоовтор манант хөндий рүү ороод их мөрний урсгал Леголасын бүргэд хараанаас алдарч байв.

Леголас нарлаг алсыг ширтэн сууж байснаа мөрний дээгүүр сүрэг цагаан шувууд нисэхийг хараад.

- Хараач, цахлайнууд! Их л хол нисч ирж дээ! Тэднийг хараад би гайхаж, зүрх түгшиж байна. Анх би тэднийг Пеларгирт онгоцнуудын төлөө тулалдаж байхдаа харсан юм. Цахлайнууд бидний дээгүүр эргэлдэн хашгиралдаад байсан. Би тэгэхэд тулалдаж байгаагаа ч мартаад алмайрчихсан, яагаад гэвэл тэдний цянгалсан урт хашгираан бол Тэнгисийн чанадаас ирсэн мэдээ байсан юм. Би тэнгисийг үзээ ч үгүй, эльф бүрийн зүрхэнд Тэнгисээ санасан гуниг байдаггүй, тэр мэдрэмжийг сэрээх аюултай гэдэг юм. Цахлайнуудын хашгиралдаанаас болоод би одоо аварга нарснуудын сүүдэр дор ч амарч чадахаа больсон.

- Мөн ярив аа! - гэж Гимли эсэргүүцэв. - Дундад газарт ч гэсэн нүд хүрэхгүй уудам талууд зөндөө л байна, харамсалтай нь эзэнгүй зэлүүд тал шүү дээ. Хэрэв эльфүүд бүгдээрээ тэнгисийн боомтууд руу явчих юм бол хаашаа ч явах газаргүй бусдынх нь амьдрал уйтгартай болно шүү дээ.

- Ямар аймшгийн уйтгартай болно гээч! – хэмээн Мерри түүний үгийг шүүрэн авч - Үгүй шүү, Леголас минь, чи тэр боомтуудаас холхон байж үз. Та нар хүмүүст ч хэрэгтэй, бидэнд ч

хэрэгтэй, энд яриад байх юм алга, гномуудад ч хэрэгтэй, мэдээжээр Гимли шиг ухаантай гномуудад. Хэрэв та нар бүгдээрээ мөхөж сөнөдөггүй л юм бол бүгдэд хэрэгтэй, мөхөж сөнөхгүй гэдэгт одоо би итгэлтэй байна. Гэхдээ одоохондоо найдварын мод дөнгөж цэцэглэж байна, үр жимсээ өгөх хараахан болоогүй. Энэ хараалт дайны эцэс харагдахгүй л байна.

- За чи битгий гуагалаад бай! – гэж Пин дуу алдаж - Нар тэнгэртээ байж байгааг чи харж байна, дахиад нэг хоёр хоног бид хамт байх болно. Би сонсох юмсан гэхээс бүр байж ядаад байна, Гимли минь! Өнөө өглөө чи Тэнэмэлтэй хамт аян дайн хийсэн тухайгаа бараг зуун удаа дурдсан байх, тэгсэн мөртөө юу ч ярьсангүй.

- Нар нараараа л байг, - гэж Гимли хэлээд – Энэ аян дайны тухай дурсахгүй байсан нь дээр, харанхуйг дуудчих ч юм билүү. Юу болохыг нь мэдэж байсан бол би үхдлүүдийн замд яагаад ч ойртохгүй байсан.

- Үхдлүүдийн зам гэв үү? - гэж Пин асуугаад - Арагорн тэр тухай ганц нэг үг унагаж байсан, би юу юм бол доо? гэж бодоод л өнгөрсөн. Тэгэхлээр чи хэлээ задлах юм биш үү?

- Тун ч хүсэхгүй байна. Тэгээд ч би тэр замд шившгээ дэлгэсэн. Глоины хүү Гимли би өөрийгөө ямар ч хүнээс илүү тэсвэртэй, газар доогуур бол ямар ч эльфээс илүү зоригтой гэж боддог байсан юм. Гэтэл дэмий тэгж бодож байсан юм билээ. Би тэр замыг зөвхөн Арагорны хүчээр л арай гэж давсан.

- Бас түүнд хайртай учраас - гэж Леголас үг нэмэрлэв. - Бид бүгдээрээ түүнийг хайрладаг. Хүн бүр өөр өөрийнхөөрөө. Мустангримийн тэр мөсөн хатан хаан хүртэл хайртай байсан. Бид та нарыг ирэхийн өмнөхөн үүрийн харанхуйгаар тэндээс мордсон юм, тэндхийн ардууд үхтлээ айдаст автсан байсан учраас ганцхан хатан хаан Эовин л биднийг үдэж мордуулсан. Гунигтай үдэлт байсан даа, би бүр урам хугарсан. Ингэхэд Мерри, бие ямар байна, эдгэрч байна уу?

- Би айснаасаа болоод хэнийг ч ажиглаагүй юм байна. Үгүй ээ, энэ тухай би ярихгүй – гэж Гимли хэлэв.

Тэгээд тэр ус балгасан юм шиг таг дуугүй суув. Пин, Мерри хоёр ч дуугарсангүй, эцэст нь Леголас.

- Тэгвэл би ярихаас даа. Дурсан санахад надад аймшигтай биш байна. Хүний сүг сүүдрүүдээс би өчүүхэн ч айгаагүй. Харин ч тэд надад хөөрхийлөлтэй, хүч чадалгүй санагдсан.

Тэгээд тэр агуйн замын тухай, Эрек уулын дэргэдэх сүг сүүдрүүдийн цугларалтын тухай, Андуины Пеларгир хүртэлх ерэн гурван бээр урт аян замын тухай товчхон ярив.

- Бид Хар чулуунаас дөрөв хоног илүү давхисан. Итгэнэ үү, байна уу өөрсдөө мэд. Мордораас илгээсэн харанхуй өтгөрөх тусам сүг сүүдрүүдийн арми улам хүч орж, аймшигтай харагдаж байсан. Тэд бидний араас довтолгож байсан, явган нь морьтойгоосоо хоцорно гэж үгүй. Мянга мянган нүд ард сүүмэлзээд л. Тийм болохоор надад улам их итгэл найдвэр төрж байсан юм. Ламедоны ууланд тэд биднийг гүйцсэн, хүйтэн сүүдрээр бүрхэх шиг болоод

бидний хажуугаар хуй салхи шиг өнгөрөх гэтэл Арагорн тэднийг зогсоогоод “Бидний араас яв” гэж тушаасан. “Энэ хүнд сүг сүүдэр, хий үзэгдлүүд хүртэл захирагдах юм. Эд бидэнд их тус болж магадгүй!” гэж би бодлоо.

Эхний өдөр л үүр дөнгөж гэгээрсэн, дараа нь гэрэл гэгээ огт байгаагүй юм шиг л, бид Кирил, Ринглог туулаад гурав дахь өдөр нь Лингир Гилраинд хүрсэн. Тэнд ламедончууд мөрнийг өгсч ирсэн далайн дээрэмчид болон өмнөдийнхөнтэй байлдаж байлаа. Гэвч хотыг хамгаалагчид болон дайснууд бүгдээрээ зэвсгээ хаяад тарж зугтаав. Үхдлүүдийн хаан өөрийн биеэр армия удирдаад ирлээ гэж хашгиралдацгааж байлаа. Ламедоны захирагч Ангбор л эр зоригтон гэдгээ үзүүлж, Арагорнтой нүүр тулж уулзахад Арагорн түүнд цэргээ нэн даруй цуглуулаад бидний араас яаран хөдөл, саарал армиас айх хэрэггүй гэж тушаасан юм.

“Исилдурын угсаа залгамжлагч та нарыг зэвсгээ барин тулалдахыг уриалж байна” – гэж тэр хэлсэн юм.

Тэгээд бид Гилраиныг гаталж, Мордорын холбоотнуудын армиудыг бут ниргээд, түр амрахаар буудаллаж байтал Арагорн босон харайж “Босоцгоогоорой! Минас-Тирит бүслэгджээ. Бид амжиж очихгүй бол тэсэхгүй байх гэж айж байна. Мориндоо!” гэж захирсан. Бид мориндоо мордоод Лебениний талаар харанхуй дундуур хурдаллаа.

Леголас яриагаа тасалж, санаа алдаад өмнө зүг рүү хандан аяархан дуулав.

Лебениний ногоон талын дундуур

Келос, Эруи голууд мөнгөрнө!

Тэнгисийн үнэрт салхинд

Тэндхийн өвс найган исгэрнэ.

Алтан мандарваа цэцгүүд

Мөнгөн хонхны дуугаар жингэнэнэ.

Лебениний ногоон талын дээгүүр

Тэнгисийн салхи үлээсэн бол!

Манай дуунуудад энэ тал ямагт ногооноороо гардаг, харин тэгэхэд хар тэнгэрийн доорх саарал тал байсан. Бид энэ өргөн талаар дайсныг их мөрний хөвөө хүртэл хөөсөн.

Тэнд би Тэнгист маш ойрхон ирээд байгаагаа мэдэрсэн юм. Бидний өмнө харанхуй усан мандал цэлийж, тэнгисийн шувуун сүргүүдийн дуу унтаа эргийг сэрээж байсан. Хурдан цахлайнуудын дуу минь дээ! Эзэн хатан намайг амар тайвнаа алдана гэж зөгнөн хэлсэн юм. Ингээд л би алдчихлаа.

- Би тэр цахлайнуудыг чинь анзаараа ч үгүй. Би агуу тулалдааныг хүлээж байсан. Тэнд

Умбарын гол флот – тавин том хөлөг онгоц байсан, жижгийг нь тоолох аргагүй. Биднээс зугтсан дайснууд тэндхийн боомтод ирж, айдас хүйдэс тарьсан учир том хөлгүүд зангуугаа татаж, мөрнөөр уруудан, жижиг онгоцууд нь бамбар шиг шатаж байлаа. Гэвч хородримчүүд ухрах газар байхгүйгээ мэдэж байсан тул байлдаанд хамаг байгаа хүчээрээ бэлтгэж байсан бөгөөд биднийг харангуугаа догдлон хөөрөлдөж байлаа. Тэгэлгүй ч яахав, бид гуч гаруй хүн, тэд зах нь харагдахгүй шороон түм.

Гэвч Арагорн жолоогоо татаж, дөрөөн дээрээ босоод аянга мэт их дуугаар. “Одоо урагшаа! Та нарыг Хар чулуугаар адислая!” гэж захирлаа. Бидний ард үзэгдэхгүй явсан саарал арми гэнэт бидний хоёр талаар уулын үер мэт хуйлран өнгөрч замдаа тааралдсан бүгдийг хуу хаман одов. Алсад хашгиралдах, эвэр бүрээний бөглүү хүнгэнээн, олон янзын хоолойн нүргээн сонсч байсан. Аль дивангарт болоод өнгөрсөн их тулааны чимээ өөр эрин цагаас сонсдож байгаа юм шиг байсан. Илдийн ир, жадны үзүүр гялс гялсхийж байх шиг харагдаж байсан, тэд цавчилдсан эсэхийг би мэдэхгүй, ямар ч гэсэн цавчих хэрэг байгаагүй. Сүг сүүдрүүд айдсаар ялдаг. Нэг ч дайсан байхгүй болсон байлаа.

Саарал армийнхан боомт дээр байгаа хөлөг онгоцууд руу дайрч, далайн дээрэмчид болон дайсны цэргүүд айсандаа ухаан алдаж, мөрөн рүү үсэрцгээж байсан. Онгоцонууд дээр зөвхөн гинжтэй боолууд үлдсэн байлаа. Бид зугтаж байгаа дайснууд дундуур эрэг рүү довтолж, дайснуудыг газарт овоорсон навчис шиг гишгилэн цавчилсаар боомтод хүрэв. Том хөлөг бүр дээр Арагорн өөрийнхөө нэг хүнийг илгээж, олзлогдсон гондор сэлүүрчдийг чөлөөлсөн.

Орой болоход тэнд дайсны сүүдэр ч үлдээгүй байлаа. Ихэнх нь живж, амьд үлдсэн нь эргэж ч харалгүй тонилсон байв. Аймшиг, харанхуйн сүг сүүдрүүд Мордорын дийлдэшгүй их хүчийг хоромхон зуурт алга болгохыг хараад би үнэхээр гайхсан. Дайсныг өөрийнх нь зэвсгээр яллаа шүү дээ!

- Гайхах юм байсан шүү - гэж Леголас батлаад - Би тэгэхэд Арагорн руу хараад бөгж эзэмшсэнийхээ дараа ямар агуу их, аюумшиггүй, бүхнийг чадагч эзэн болох бол гэж бодсон. Мордорын эзэд түүнээс тэглээ айдаг нь дэмий хэрэг биш байж. Түүний зүрх сэтгэлийн цэвэр ариун Сауроны ид шид, эрлэгийн ухааныг ялж байна. Арагорн Лучиэний удам биш гэж үү? Энэ омог үеийн үед айдас, зэмлэл хоёроос чөлөөтэй байх болно.

- Гномууд тийм хол хардаггүй – гэж Гимли хэлээд – Гэхдээ тэр өдөр Арагорн үнэхээр агуу эзэн байсаан. Хар флотыг эзэлж аваад тэр хамгийн том хөлгийн цамхаг дээр гарч, дайснуудын орхисон бүх бүрээгээр бүрээдэхийг тушаасан. Саарал арми эрэг дээр жагсаад чив чимээгүй хүлээж байсан, тэдний дүрс бараг үзэгдэхгүй, зөвхөн шатаж байгаа хөлгүүдийн улаан туяанд тэдний нүд гэрэлтэж байв.

Тэгээд Арагорн сүг сүүдрүүдийн армид хандаж, аянга нүргэлэх мэт их дуугаараа

“Исилдурын угсаа залгамжлагчийн үгийг сонс! Та нар нэгэн цагт няцсан тангаргаа үнэнчээр биелүүллээ. Өөрсдийнхөө хязгаарт эргэн очицгоо, тэндхийн оршин суугчдыг бүү айлгаж цочооцгоо! Амар тайван нойрсоцгоо!” гэж захирав.

Үхдлүүдийн хаан урагш давшин гарч ирээд жадаа хугалж, хугархайг нь газарт унагаад,

Арагорнд гүнээ мэхийн ёслоод эргэлээ. Тэгээд л саарал арми хоромхон зуурт салхинд туугдан сарних манан адил үгүй болсон. Би зүүдлээд сэрлээ л гэж бодож байлаа.

Тэр шөнө бид амарч, бусад маань гар хумхилгүй ажилласан. Яагаад гэвэл бид хэдэн мянган олзлогдсон гондорчууд, далайн дэрэмчдийн боолуудыг чөлөөлсөн юм. Удалгүй Лебеннинаас хүмүүс мянга мянгаараа ирсэн, Ламедон Ангбор бүх морьт дайчдаа авчирсан. Манай сүг сүүдрүүд алга болсон тул хүмүүс айх юмгүй болж, бидэнд туслахаас гадна Исилдурын залгамжлагчийг харахыг хүсч байлаа. Түүний тухай домгийг тэр шөнийн галт мөр үлдээсэн.

За ингээд бидний аян дайны түүх бараг дуусч байна даа. Орой, шөнө хоёрт хөлөг онгоцуудыг аялалд бэлтгэж, шинээр далайчид элсүүлж, дарга нарыг нь сонгосон, тэгээд л өглөө эрт хөдөлсөн. Дунхергээс гарснаас хойш зургаа дахь өдөр буюу уржигдар боловч бүр дээр үед болсон юм шиг санагдах юм. Арагорн хожимдох вий гэхээс айсаар байв.

“Пеларгираас Харлондын боомт хүртэл дөчин хоёр бээр. Хэрэв бид маргааш Харлонд хүрэхгүй бол бүх юм дууссан байна” гэж тэр хэлж байсан.

Сайн дурынхан сэлүүр дээр сууж, байдаг хүчээрээ сэлүүрдэж байлаа, гэлээ ч гэсэн бид эхлээд удаан урагшилж байсан. Ямар ч гэсэн урсгал сөрж яваа, тэгэхээс тэгэх гэсэн юм шиг салхи байдаггүй. Би бүр сэтгэлээр унаж “Ялах нь ч яллаа, ялсны хэрэг гарахгүй нь” гэж бодож явгал Леголас гэнэт инээж.

“Сахлаа дээш нь, Дарины удам минь! Ангал руу нисэнгүүт найдвар төрдөг гэж ярьдаг шүү дээ” гэдэг юм байна. Найдвар яах гэж төрдгийг харин тайлбарласангүй. Шөнийн харанхуй өдрийн харанхуйгаас арай дээр боловч дэндүү уйтгартай байв. Тэртээ хойно тэнгэрийн хаяан дахь үүлэнд улаан гэгээ татахад Арагорн “Минас-Тирит шатаж байна” гэлээ.

Шөнө дунд үнэхээр найдвар дахин төрлөө. Онгоцны хошуун дээр байсан далайчид өмнө зүг рүү харж байгаад Тэнгисээс шинэ салхи үнэртэж байхыг мэдэрчээ. Нэн даруй далбаагаа өргөн, улам хурдан хөвсөөр үүр цайх үед онгоцны ус зүсэгч дээр хөөс тодорч ирэв. Цааш нь та нар мэдэж байгаа. Нар голлох үеэр бид арын салхинд хөөгдөн ирж, байлдааны тугаа өргөсөн. Дараа нь юу ч боллоо гэсэн энэ бол агуу өдрийн мартагдашгүй цаг.

- Дараа нь юу ч боллоо гэсэн гавьяа бүдгэрэхгүй – гэж Леголас хэлээд - Үхдлүүдийн замаар хийсэн аян дайн бол гавьяа, дараа нь Гондор хоосорч, эзэнгүй болсон ч энэ гавьяаны агуу нь алга болохгүй.

- Тиймэрхүү л юм болж байх шиг байна даа, - гэж Гимли хэлээд - Гэндалф Арагорн хоёрын царай тун ч баргар байна. Тэд асарт юун тухай зөвлөлдөж байгааг мэдэх юмсан! Би Меррийн адилаар энэ хараалт дайны эцсийг үзнэ гэж найдахгүй байна. Гэвч яалаа ч гэсэн би Гоонь уулын гномуудын нэр төрийн төлөө цаашид тулалдахад бэлэн байна.

- Би Бөглүүд ойн эльфүүдийн төлөө, Цагаан модны орны эзэн хааны төлөө - гэж Леголас хэлэв.

Андууд яриагаа зогсоож, хүн бүр өөрийнхөө бодолд автан хэрэм дээр удаан дуугүй сууцгаав.

Удирдагчид зөвлөлдсөөр байлаа.

Леголас Гимли хоёроос салаад Имраиль ван Эомер руу яаралтай элч илгээгээд, нам гүм болсон хотын гудамжаар бууж, Арагорны асраа босгосон талд ирэв. Эзэн захирагч Теоден эндээс холгүй тулаанд унасан билээ. Арагорн, Гэндалф болон Элрондын хөвгүүд тэднийг хүлээж байв.

- Эрхэм эзэд минь, - гэж Гэндалф зөвлөгөөнийг эхлээд - Би та нарт Гондорын эзэн захирагч үхэхийнхээ өмнө юу гэж хэлснийг дамжуулъя. “Магадгүй та нар Минас-Тиритийн хэрмийн дэргэд ялж болох юм, гэвч та нарын дээрээс далайсан цохилтыг няцаах аргагүй”. Тэр энэ үгийг цөхөрч, аргаа барсан үедээ хэлсэн боловч энэ үгэнд үнэний хувь нэлээд байна.

Нүдэн чулуунууд худлаа хэлдэггүй, тэднээр худлаа хэлүүлэх боломжгүй, эзэн нь болсон Барад-Дурд ч тийм чадал байхгүй. Тэр дайснаа дийлээд нүдийг нь өөр тийш харуулах юм уу, харсан зүйлийг агуулгыг мушгин гуйвуулж чадна. Гэвч, Денэтор хүртэл үнэхээр Мордорын өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байгаа хэмжээ хязгааргүй их хүчийг харсан нь илт байна.

Бид эхний довтолгоог арайхийн няцааж чадлаа. Одоо удахгүй түрүүчийнхтэй зүйрлэшгүй их хүчээр довтолно. Бидэнд ялах найдвар байхгүй, энэ талаар Денэтор үнэн хэлсэн. Эндээ үлдээд, дараалсан бүслэлтийг тэсэн тэссээр үхэж дуусах уу, эсвэл Мөрний цаана хүч тэнцвэргүй тулалдаан хийж үхэх үү гэдэг ялгаагүй. Зөвхөн хоёр зовлонгийн арай багыг нь сонгох боломж байна. Мэдээж өөрийнхөө цайзад хориглоод удаан биш ч гэсэн тэсч, бүх нийтээр үхэх аюулыг хойшлуулсан нь дээр.

- Тэгэхээр чи Минас-Тирит, Дол-Амрот, Дунхергт бэхлэн суугаад далайн түрлэг болж байхад элсэн цамхаг барин тоглож байгаа хүүхдүүд шиг сууж байя гэсэн зөвлөгөө өгч байна уу - гэж Имраиль асуув.

- Тийм зөвлөгөө үнэ багатай, - гэж Гэндалф хариулаад - Денэторийн үед ингэж суусан нь багадлаа гэж үү? Үгүй! Ингэх нь эрүүл ухааны шийдвэр гэж би хэлсэн, гэвч би ийм эрүүл ухаанд уриалаагүй байна. Бидэнд ялах найдвар байхгүй, гэвч бид ялж чадна, гэхдээ цэрэг зэвсгийн хүчээр биш гэж хэлсэн. Ялалтыг бүгдийг захирагч бөгж шийднэ. Энэ бөгж бол Барад-Дурын хэзээ ч, хэнд ч ялагдашгүйн баталгаа, бас Сауроны агуу их найдвар.

Эрхэм эзэд та нар тэр бөгжний талаар хангалттай мэднэ, ямар ч гэсэн миний юу ярьж байгааг ойлгох хэмжээнд хангалттай мэднэ. Түүнээс бидний хувь заяа хамаарна. Сауроны ч хувь заяа хамаарна. Хэрэв түүний гарт бөгж дахин орвол та нарын гавьяа мартагдана. Тэр маш хурдан, маш хөнөөлтэй ялна, тэр энэ ертөнцөд цаг хугацааг дуустал эзэн суухаар тийм хөнөөлтэй ялна. Хэрэв бөгжийг устгачих юм бол Саурон ор мөргүй алга болно, цаг хугацааны төгсгөл болтол өндийж ирэхгүйгээр алга болно. Учир нь тэр эхлээд олж авсан бүх хүч чадлаа алдана, тэгээд түүний эрх мэдлээр бий болсон бүх юм нурна, тэр өөрөө ёроолгүй харанхуйд үүрд үлдэж, дахин бүрэлдэж, гарч ирж чадахгүйн улмаас өөрийгөө мэрээд дуусна. Ингээд ертөнцийг эзлэх гээд байгаа адын хар аюул, сайн бүхний дайсан, муу бүхний үр ертөнцөөс үүрд алга болно.

Дараа нь ертөнцөд өөр ийм аюул зайлшгүй гарч ирнэ, бүр илүү хүчтэй аюул ч гарч ирж

болно, бүр олон аюул ч гарч ирж болно. Яагаад гэвэл Саурон ердөө л зарц, хөрс бэлтгэгч. Гэвч энэ бол бидний санаа зовох зүйл биш. Бид ертөнцийг мөнхөд сайжруулах үүрэгтэй биш, бид зөвхөн өөрийнхөө амьдарч байгаа цаг үеийг л хариуцна, бид хөнөөлт хог ургамлыг үндсээр нь устган, үр удамдаа цэвэр тариан талбай бэлдэж өгөх үүрэгтэй. Бид тэдэндээ сайхан цаг агаар үлдээж чадахгүй.

Саурон өөрт нь ямар аюул нүүрлэж байгааг мэдэж байгаа, алдсан бөгж нь олдсон гэдгийг мэдэж байгаа. Тэр зөвхөн бөгж одоо хаана байгааг л мэдэхгүй байгаа, мэдэхгүй байгаа гэж найдахаас. Тийм учраас тэр эргэлзээнд идэгдэж байгаа. Бидний зарим нь тэр бөгжийг олоод авчаж чадна гэдгийг тэр бас мэдэж байгаа. Арагорн, чи Ортханкийн нүдэн чулуугаар тэрэнд үзэгдсэн гэж би зөв ойлгож байна уу?

- Тийм ээ, Горнбургээс гарахын өмнө, - гэж Арагорн нотлоод. - Цаг нь болжээ, тийм учраас л тэр чулуу миний гарт орлоо гэж ойлгосон. Тэгэхэд бөгж хадгалагч Рэросаас дорно зүг яваад арав хонож байсан, бас Сауроны нүдийг ч Мордороос холдуулах хэрэгтэй гэж би шийдсэн юм. Тэрнийг хар цамхагт нь хэн ч санааг нь зовоож байгаагүй. Хэрэв тэр ингэж их сандарч, ийм их бэлэн хүчээ ийм хурдан хөдөлгөхийг нь би мэдсэн бол арай болгомжтой хөдлөх байсан. Би жаахан л алгуурласан бол та нарт туслахаар ирж амжихгүй байсан.

- Энэ чинь юу гэсэн үг вэ? – гэж Эомер асуугаад – Гэндалф чи Саурон бөгжийг олчихвол бүх юм баларна гэсэн. Хэрэв тэр бөгжийг бидний гарт байгаа гэж бодож байгаа бол биднээс яагаад айхгүй байгаа юм бэ?

- Тэр үүнд бүрэн итгэлтэй биш байна, тэгээд ч бидэн шиг дайснаа түрүүлж довтлохыг хүлээж сууж сураагүй юм - гэж Гэндалф хариулаад. – Бөгжийг хэн нэгэн шууд эзэмшиж чадахгүй гэдгийг тэр мэдэж байгаа, тэгээд ч бөгж ганцхан л эзэнтэй байх ёстой, тэгэхлээр бидний гарт бөгж орсон бол бид заавал муудалцана гэж тэр тооцоолсон. Бөгж хэний гарт байна, тэр дайснаа хиар цохино. Дараа нь бөгж тэрнээс урваад Сауронд үйлчилнэ.

Тэр биднийг ажиглаж байгаа, тэр олон юм сонсч, олон юм үзэж байгаа. Тэрний тагнуул хар сүүдрүүд газар сайгүй нисч байгаа. Өнөө өглөө үүрээс өмнөхөн тэд Пеленнорын дээгүүр нисч өнгөрсөн, ядарсан, ид нойрондоо байсан дайчдаас хэн ч анзаараагүй байх. Тэр их түгшүүртэй тэмдгүүдийг ажигласан нь мэдээж. Тэрний хурууг бөгжтэй нь хамт тас цавчсан илдийг шинээр давтсан байна. Салхи чиглэлээ өөрчилж, үүлсийг хөөгөөд, хөлөг онгоцнуудыг тээж одсон, шороон түмэн цэрэг нь яагаад ч юм хоромхон зуурт ор мөргүй болтлоо бут цохигдсон, дээрээс нь нэмээд хамгийн хүчирхэг жанжин нь алагдсан.

Тэрний сэжиг таамаг цаг минутаар лавширч байгаа. Тэрний нүд бидэн дээр төвлөрсөн, бусдыг нь төдийлөн анзаарахгүй байгаа. Тэгэхлээр бид тэрний нүдийг өөр дээрээ наах хэрэгтэй. Үүнд л бидний бүх найдвар байна. Миний өгөх зөвлөгөө энэ л байна. Бөгж бидэнд байхгүй. Мэргэн шийдсэн үү, тэнэг шийдсэн үү. Ямар ч байсан тэрнийг устгахаар илгээсэн, тэгэхгүй бол биднийг устгана. Бөгжгүйгээр бид Сауроныг дийлэхгүй. Гэвч тэрний нүд жинхэнэ аюулыг харах ёсгүй. Бид баатарлаг гавьяагаараа ялалтад хүрэхгүй, гэвч хадгалагчийн амжилт хичнээн эргэлзээтэй ч гэсэн бидний баатарлаг гавьяанаас хамаарна.

Арагорн яаж эхэлсэн бэ, яг л тэрэн шиг үргэлжлүүлж, Сауронд эргэж харах боломж өгөхгүй

байх хэрэгтэй. Тэр бүх хүчээ шийдвэрлэх цохилт өгөхөөр цуглуулж, хар хаалганууд дээрээ бөөгнөрүүлэн, Мордор хамгаалалтгүй үлдсэн байх хэрэгтэй. Нэн даруй аян дайнд мордох хэрэгтэй. Бид тэрэнд өөш болно, тэгэхдээ жинхэнэ өөш болно. Тэр өөшийг шунахайран шүүрч авна. Учир нь тэр бидний ийм хуумгай байдал бол бөгжний шинэ эзний хэнд ч, юунд ч дийлдэшгүй бардам ихэрхэл, хурдан ялж ертөнцийг эзлэх боломж гэж бодно. Тэр өөртөө ингэж хэлнэ. “Аах, тийм би чи! Хурдан гараад ирлээ дээ чи, арай л дэндүү зориглолоо доо чи. Ойртоод ирэг – урхинд орог. Тэр дор чинь чамайг дуусгаад өгнө, чиний халдсан тэр юм чинь үүрд минийх болно”

Бид тэрний урхинд орох хэрэгтэй, санаатайгаар, эргэж ч харалгүйгээр, амьд үлдэнэ гэсэн найдлагагүйгээр орох хэрэгтэй. Бид төрөлх газраасаа алс газарт тулалдаанд унах байх, Барад-Дур сөнөлөө ч гэсэн бид үзэхгүй байх. Гэвч бидэнд ийм л хувь тохиолоо. Үхлээс бид тэртэй тэргүй зайлахгүй - үхлийг хүлцэнгүй хүлээснээс энэ нь дээр бус уу? Үхэхдээ ирээдүй үе гэж байхгүй гэж бодсоноос байгаа гэж бодох нь дээр биш үү?

Асарт нам гүм. Эцэст нь Арагорн хэлэв.

- Буцах зам би олж харахгүй байна. Бид ангалын ирмэг дээр байна, найдвар гэдэг цөхрөлтэй адилхан. Эргэлзэнэ гэдэг унана гэсэнтэй адил байх. Бүгд Гэндальфын зөвлөгөөг анхааралтай сонс. Тэр аль эртнээс Сауронтой тэмцэж ирсэн, тэр тэмцлийн төгсгөл одоо шийдэгдэх гэж байна. Хэрэв Гэндальф байгаагүй бол өдийд аврах юм юу ч байхгүй болох байсан. Би хэнд ч тулгах гээгүй, хүн бүр өөрөө шийд.

Элроир хэлэв.

- Ингэх гэж л бид умардаас ирсэн. Бидний эцэг Элронд ч гэсэн Гэндальфтай ижил зөвлөгөө өгсөн. Бид ухрахгүй ээ.

- Миний хувьд ийм нарийн зүйлийг сайн ойлгохгүй, гэвч бүх юм тодорхой байна. Би нэг л зүйлийг сайн мэдэж байна. Миний анд Арагорн намайг болоод манай ард түмнийг аюулаас аварсан, хэрэв түүнд миний тусламж хэрэгтэй байгаа бол түүнтэй хаашаа ч хамаагүй явна – гэж Эмроэл хэлэв.

- Би өөрийгөө эзэн хаан Арагорны улсын ерөнхий жанжин гэдгээ тэр хаан ширээндээ хараахан суугаагүй байгаа ч гэсэн хүлээн зөвшөөрч байна. Тэрний үг надад хууль. Би ч гэсэн хамт явна. Гэвч тэр өөрөө намайг Гондорын эзэн захирагчаар томилсон, тиймээс би юуны өмнө гондорчуудын төлөө санаа зовох ёстой. Бага зэрэг эрүүл ухаан ямар ч гэсэн саад болохгүй. Аль аль төгсгөлийг харгалзах хэрэгтэй. Хэрэв бид ялах юм бол, ядаж өчүүхэн ч гэсэн найдвар байгаа бол Гондорт хамгаалалт хэрэгтэй. Би ялалт байгуулчихаад сүйрсэн хот, үгүйрсэн оронд ирмээргүй байна. Түүнээс гадна умар зүгээс бидэн рүү их цэрэг ирэх гэж байгааг би мустангримчүүдээс мэдсэн.

- Энэ үнэн, - гэж Гэндальф батлаад – Би хотыг хамгаалалтгүй үлдээх тухай бодоогүй шүү. Бидэнд тийм ч их цэрэг хэрэггүй. Бид Мордоргыг эзлэхээр мордохгүй, тулалдаанд үхэх гэж л явах болно. Өнөө маргаашгүй гарах хэрэгтэй байна. Би яг асуух гэж байсан юм. Хоёр хоногийн дотор бид хичнээн дайчин цуглуулж чадах вэ? Тэд бол баатарлаг дайчид, тэгэхдээ

юу руу явж байгаага мэдсэн сайн дурынхан байх ёстой.

- Бүгд эмээл дээрээ арайхийн тогтож байна, бараг бүгдээрээ шархадсан. Тэгэхлээр хоёр мянгыг цуглуулж чадах уу үгүй юу, энд бас түүнээс цөөнгүйг үлдээх хэрэгтэй.

- Манай хүч санаснаас их байна – гэж Арагорн хэлэв. – Өмнөдөөс нэмэлт хүч ирнэ. Эргийн хамгаалалтын дайчид. Хоёр хоногийн өмнө би Пеларгираас Лоссарнахаар дамжуулан дөрвөн мянган дайчин мордуулсан, тэднийг аймшиггүй Ангбор захирч яваа. Хэрэв бид хоёр хоногийн дараа хөдөлбөл тэд зөрөөд орж ирнэ. Бас гурван мянган дайчинг Мөрнөөр онгоц, завиар гаргасан, салхи одоохондоо туусан хэвээр байгаа, Харлонд хэд хэдэн онгоц ирсэн байна. Товчхондоо бид долоон мянган явган цэрэг, морьт цэрэг цуглуулна. Энэ бол бүслэлтийн эхний хүчнээс их байна.

- Хаалганууд эвдэрсэн шүү дээ, манайд тийм мастерууд байхгүй, хэнээр сэргээлгэх юм бэ - гэж Имраиль хэлэв.

- Эреборт, Дайнагийн уулан доорх вант улсад тийм мастерууд бий, хэрэв бидний найдвар биелбэл би Глоины хүү Гимлигээс хамгийн сайн мастеруудаа аваад ир гэж гуйна. Гэвч хүмүүс хаалганаас найдвартай шүү дээ, хамгаалагчид дутагдвал хамгийн сайн хаалга ч дайсны түрэлтэд тэсэхгүй – гэж Арагорн хэлэв.

Удирдагчдын зөвлөгөөн ийнхүү дуусав. Нөгөөдөр өглөө долоон мянган дайчин аян дайнд хөдөлнө, ихэнх нь явган цэрэг байна. Арагорн Андуинаас өөртэй нь хамт ирсэн дайчдаас хоёр мянгыг нэмнэ гэж амлав. Имраиль гурван мянга таван зуу, Эомер таван зуун мустангримчүүд, Арагорн өөрөө таван зуун морьт дайчдаас бүрдсэн сонгомол бүлэг, түүний дотор Элрондын хөвгүүд, дунаданчууд, Дол-Амротын баатар вангууд, нийтдээ зургаан мянган явган дайчин, мянган морьт дайчин гаргахаар боллоо. Мустангримын морьт дайчдын ихэнх буюу гурван мянган дайчинг Эльфхельмээр захируулан Анориэн дэх дайсны бүлэглэлийн өөдөөс илгээхээр болов. Мөн умард болон зүүн зүг рүү Осгилиатаас цааш, Минас-Моргулын зам руу тагнуулчдыг илгээхээр боллоо.

Тэд дайчдаа тоолж, хуваасны дараа Имраиль гэнэт чангаар инээв.

- Гондорын түүхэнд ийм инээдэмтэй юм болж байгаагүй. Долоон мянган дайчин толгойн сэргийлэх ангид ч багадна, гэтэл бид тэднийг нэвтэршгүй хүчирхэг цайз руу явуулж байдаг. Авч болшгүй, хаяж ч болшгүй жаалхүү хуяг дуулгатай дайчин ван руу дэрсэн сумтай тоглоомын нумаар харвалдах гэж байгаа юм шиг! Хар эзэн бүгдийг хардаг, бүгдийг мэддэг гэж Митрандир чи яриа биз дээ. Магадгүй тэр болгоомжлохын оронд мушилзан инээгээд, биднийг хамар дээр суусан шумуул шиг чигчий хуруугаараа дарчих юм биш биз?

- Үгүй ээ, тэр шумуулыг барьж аваад, хошууг нь сугалахыг оролдоно, бидний дотор лав мянган хуяг дуулгатай дайчин вантай тэнцэх дайчид ч бий. Тэр инээхтэй манатай болох вий - гэж Гэндальф хэлэв.

- Бидэнд ч гэсэн ялгаагүй. Инээдтэй байж болох юм, гэвч инээх нэг л дургүй байх чинь. Үхэх сэхэхээ үзэх цаг ирж байна. Бид сонголтоо хийсэн, одоо хувь тавилангийн ээлж – гэж Арагорн

хэлээд Анрил илдээ сугалан өндөр өргөв. Нарны гэрэлд илдний ир шатаж байх шиг. –
Сүүлчийн тулалдаан дуустал хуйндаа орохгүй нь дээ чи – гэж тэр хэлэв.

Бүлэг 10

Хаалга нээгдэв

Үүнээс хоёр хоногийн дараа өрнөдийн орнуудын шилмэл цэрэг Пеленнорын талд жагсав. Орхууд болон вастакууд Аноризениос довтолсон боловч мустангримчүүд тэднийг угтаж, төвөггүй бутцохин Мөрнөөс цааш, Каир-Андрос руу хөөж гаргав. Минас-Тиритийн хамгаалалт өмнөхөөс хавьгүй хүчтэй болж, өмнөдөөс нэмэлт хүч өнөө маргаашгүй ирэх гэж байлаа. Тагнуулчид эргэж ирээд дорнын зам дээр дайсны цэрэг алга байна, эртний эзэн хааны чулуун хөшөө хүртэл, уулзвар хүртэл замд хэн ч алга байна гэж илтгэв. Мөхөл рүү явах зам чөлөөтэй байгаа ажээ.

Леголас, Гимли хоёр мэдээж тэргүүн хороог захирч байгаа Арагорн, Гэндальф хоёроос хоцорсонгүй, энэ хороонд бас дунаданууд, Элрондын хөвгүүд байлаа. Мерри яаж ч гуйгаад түүнийг авсангүй.

- Чи яаж явах юм бэ? - гэж Арагорн асуугаад – Битгий гунь, чи өөрийнхөө гавьяаг байгуулчихсан, чиний гавьяа хэзээ ч мартагдахгүй. Перегрин бидэнтэй хамт явж, Хоббитанийхаа төлөө тулалдана. Тэр замын ая даана, харин чиний хувьд хол зам шүү дээ. Үхлийг хайх хэрэггүй, тэр тэртэй тэргүй амьтай бүхний толгой дээр өлгөөтэй байгаа. Бид Мордорын хаалганы дэргэд түрүүлж үхэх байх, чиний ээлж энд ч юм уу өөр хаа нэгтэй ирнэ. Баяртай!

Ингээд Мерри гунигтай царайлан дайчид хэрхэн жагсч байгааг харж зогсов. Түүний дэргэд Бергил зогсоно. Түүний аав цайзын хамгаалалтаас хөөгдсөн тул энгийн дайчдын нэг отрядыг захиран явахаар болсонд бас нүд дүүрэн нулимстай байв. Тэр отрядад Минас-Тиритийн хамгаалагч Пин байв. Мерри өндөр өндөр гондоруудын дундах жижигхэн дайчин руу ширтсээр зогсов.

Бүрээ хүнгэнэж, дайчид хөдөллөө. Тэд бүлэг бүлгээрээ, отряд отрядаараа эгнэн зүүн зүг рүү одов. Мерри далан дээр зогсоод тэднийг далд ортол хойноос нь ширтсээр байлаа. Өглөөний нар дайчдын дуулга, жадны үзүүрт сүүлчийн удаа гялсхийсэн ч тэр толгой унжуулан зогссоор, зүрх нь шимширч байх шиг. Тэр тун ч их ганцаардав. Найзууд нь бүгдээрээ дорноос сүүдэрлэж байгаа харанхуй руу явчихлаа. Тэдэнтэй дахин уулзах бараг ямар ч найдвар байхгүй байлаа.

Гэнэт сэтгэлийн гунигаас болсон юм шиг баруун гар нь янгинан өвдөж, хамаг бие нь сулраад, найган ганхаж, нарны туяа бүдэгрэв. Бергил түүний мөрнөөс татаж.

- Явья, ноёнтоон! Таны бие муу байна. Зүгээр, би таныг Анагаах танхимд хүргээд өгнө. Та битгий ай, тэд нар эргээд ирнэ! Манай минастиритчүүдийг хэн ч, хэзээ ч дийлэхгүй. Цайзын хамгаалалтын Берегонд гэхэд л ганцаараа хэдэн арван дайсантай тэнцэнэ, тэгээд ч одоо тэдэнтэй эзэн хаан Элессар байгаа!

Үдээс өмнөхөн тэд Осгилиатад орж ирэв. Тэнд мастерууд гар хумхилгүй хөдөлмөрлөж

байлаа. Гаталга завь болон хөвөх гүүрийг засч, агуулахуудыг дахин барьж нөөцөөр дүүргэж байв. Мөрний зүүн талд бэхлэлтийг маш хурдан босгож байна.

Тэд эртний нийслэлийн туурийг өнгөрч, их мөрнийг гатлаад нэгэн цагт Жаргах нарны цайзыг Мандах сарны цайзтай холбож асан, дараа нь хар шидэнд автаж аймшгийн хөндийн цайзууд болсон Минас-Моргул, Моргулийн замаар өгсөв. Осгилиатаас цааш таван бээр яваад хоноглохоор зогслоо. Гэвч тэргүүн хорооны морьт дайчид модон багануудад хүрчээ. Эргэн тойрон чив чимээгүй. Дайснууд ч үзэгдсэнгүй, хоорондоо дуу чимээ авалцсангүй, асга хадан хясаа болон замын хажуугийн бутны цаанаас нэг ч сум нисч ирсэнгүй, гэвч газар тун их сэрэмжтэй байгааг, тэднийг чулуу, мод бүхэн, өвс навч бүр ажиглаж байгааг дайчид мэдэрч байв.. Харанхуй аргаш ухарч, тэртээ баруун зүгт шингэсэн нарны сүүлчийн туяа Андуиныг туяаруулан, цэлмэг тэнгэрт уулсын цаст оргилууд улайрч харагдана. Харин Эфель-Дуат ердийн заналт харанхуйд хучигджээ.

Арагорн дөрвөн зүгт бүрээчдийг илгээж, “Тондорын эзэд уугуул нутагтаа эргэн ирлээ!” гэсэн дохиог бүрээдэхийг тушаав. Чулуун хөшөөний мөрөн дээрээс жихүүдэс хүрэм муухай царайт чулуун толгойг унагаж хага цохиод, амьд ургамлаар хийсэн титэмтэй эртний эзэн хааны чулуун толгойг суулгав. Хөшөөнөөс орхуудын огиудас хүрэм буржгар үснүүдийг хусч цэвэрлэв.

Имраиль Минас-Моргулыг ганцхан дайралтаар эзэлж, энэ заналт цайзыг газрын хөрснөөс арчъя гэсэн санал тавилаа.

- Тэгээд ч Мордорт нэвтрэх аргагүй, умард хаалгаар нь орох гэж зүтгэхийн оронд Моргулын даваагаар давж орсон нь дээр биш үү - гэж тэр хэлэхэд Гэндалф энэ саналыг хүлээж авсангүй.

- Моргулийн хөндий урьдын адил айдас, солиорлоор заналхийлж байгаа, тэгээд ч Фродо тийшээ явсан гэж Фарамир ярьсан, тэгэхлээр Мордорын нүдийг өөр тийш чиглүүлэх хэрэгтэй -гэв.

Өглөө нь дайчид боссоны дараа Уулзварт томоохон бүлэг үлдээх хэрэгтэй гэж шийдэв. Өмнөдөөс дайсны цэрэг даваагаар давж ирвэл энд нь цохих хэрэгтэй гэж удирдагчид үзжээ. Гол төлөв нутгийн болон Италийн харваачдыг үлдээж, тэд уулын хажуу болон ойн төглөөр таран байрлалаа. Гэндалф, Арагорн хоёр морьт хороотойгоо хөндийд орж ирэхэд харанхуй, хоосон цайз угтлаа. Орхууд болон мордорын бусад бузар хүчнийг Минас-Тиритийн ханын дэргэд хүйс тэмтэрсэн, хар сүгнүүд тал тал тийш тагнуулд явсан байв. Гэвч хөндийн бүгчим агаараас үхэл үнэртэж байлаа. Дайчид шидийн гүүрийг нурааж хаяад, хорт нугыг галдан шатааж орхиод цааш хөдлөв.

Гурав дахь өдөр нь дайчид умардын замаар урагшиллаа. Уулзвараас Мораннон хүртэл зуу гаруй бээр бөгөөд энэ замд ямар ч сайн юм тааралдахгүй нь мэдээж байлаа. Дайчид нуугдалгүй явсан боловч ихэд болгоомжтой байв. Урдаа морьт тагнуулчдыг, баруун зүүн тийш явган тагнуулчдыг илгээлээ. Зүүнээс Изгарын уулс уйтгартай дүнсийж, түүний налуу хажуу тал нь гуу жалга, бараан өнгөт мод бутаар хүрээлэгджээ. Цаг агаар тунгалаг хэвээр, баруунаас салхитай байв. Гэвч Эфель-Дуат урьдын адил өтгөн мананд хучаастай, түүний цаанаас бөөн

хар угаа хөөрөн үүл болжээ.

Гэндалфын тушаалаар байн байн бүрээдэж, херальдууд “Гондорын эзэд эргэж ирлээ! Энэ газрыг орхицгоо, эсвэл ялагчийн ивээлд бууж өгцгөө!” гэж өндөр дуугаар зарлаж байв. Имраиль хэлэв.

- Гондорын эзэд гэж битгий зарла, эзэн хаан Элессар гэж зарла. Тэр хаан ширээндээ залраагүй ч энэ бол үнэн. Дайсан түүний нэрийг байнга сонсч байг! – гэв.

Херальдууд гурван удаа эзэн хаан Элессар эргэн ирлээ гэж зарлав. Гэвч ямар ч хариу сонсогдсонгүй.

Дайснууд үзэгдээгүй боловч жанжнаасаа цэргээ хүртэл бүх дайчид нэг л түгшүүртэй, баргар царайлж байлаа. Уулзвараас гарснаас хойш хоёр дахь өдрийн төгсгөлд дайснууд анх үзэгдэв. Фарамир хородримчүүдийг отоож цохисон тэр газарт үй олон вастак болон орхууд хориглосон байлаа. Тэндхийн зам Эфель-Дуатыг хоёр хэсэгт хуваасан хавцал дундуур гардаг билээ. Гэвч Маблунгийн захирсан толгойн сэргийлэхийн ангийн дайчид – голдуу Италийн мөрчид гэнэдэж сандарсангүй, отолтыг бахинд хавчив. Морьтон дайчид отолтын зүүн талаар тойрон ард нь гарч, дайснуудыг бараг бүгдийг нь хиар цохин, амьд үлдсэн нь Изгарын уул өөд зугатав.

Гэвч удирдагчид энэ хөнгөн ялалтад төдийлөн баярласангүй.

- Энэ бол бид дайсны хүчийг сулхан гэдэгт итгэж, ухралтгүй давших боломж олгож байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл биднийг урин дуудаж, өөш хаяж өгч байгаа юм - гэж Арагорн хэлэв.

Тэр үдэш тэдний дээгүүр хар сүгнүүд араасаа их цэрэг дагуулан нисч өнгөрөв. Тэд маш өндөрт нисч байсан тул ганцхан Леголас л харав. Бөгжтөн сүгнүүд сүнс зайлтал хашгираагүй, доошилж ирээгүй боловч дайчдын бие жихүүцэн зүрх чичирч байлаа.

Найдваргүй аян дайны эцэс ойртож байв. Уулзвараас гарснаас хойш дөрөв дэх, Минас-Тиритээс гарснаас хойш зургаа дахь өдөр дайчид Кирит-Горгорын хавцлын өмнөх хордуулсан талбайд орж ирлээ. Эргэн тойрон хов хоосон, ямар ч амьдралын шинж тэмдэггүй. Баруун хойт зүгт намаг ба хоосон тал. Амьдралгүй энэ газарт аймшигтай зэвүүн байсан тул айдаст баригдсан зарим дайчин хөдөлж ч чадахгүй байлаа.

Арагорн алсын Вестфольдын адуучин залуус, Лоссарнахын тариачдыг огт уур хилэнгүй, өрөвдсөн харцаар харж байв. Тэд хүүхэд наснаасаа Мордороос айж өссөн, гэхдээ тэр айдас нь ердөө л аймшигтай нэр төдий байсан бөгөөд тэдний амьдрал хэвийн байдлаараа л явж байсан билээ. Харин одоо хар дарсан зүүд бодит биеллээ олж, ямар гээчийн хачин дайн болоод байгаа юм бэ, ямар хувь заяа тэднийг ийш нь шидчихсэн юм бэ гэдгийг мэдэхгүй байлаа.

- Явцгаа! – гэж Арагорн тэдэнд хэлээд. - Гэхдээ ухарч зугтааж болохгүй, дайчны нэр төрийг хайрла. Дараа нь ичиж үхэхгүйн тулд та нарын хүчинд тохирсон даалгавар өгье. Баруун өмнө зүгт Каир-Андрос руу яв. Тэрнийг дайсан эзэлсэн байх ёстой. Тэднийг хиар цохь! Гондор

болон Ристанийн төлөө эцсээ хүртэл тулалдаж Каир-Андросыг чөлөөл!

Залуу дайчдын зарим нь хааны хатуу өршөөлөөс ичиж, айдсаа даран эгнээндээ орж, зарим нь шившгээ тарихаас айсан уу, тулалдаанд шалгаран гавьяа байгуулахыг хүссэн үү, баруун өмнөө зүг рүү явлаа. Цэргийн тоо багассаар. Уулзварын тэнд цөөнгүй дайчин үлдээсэн билээ. Өрнөдийн орнуудын хаад эгнэгт эвдэршгүй Мордорын Хар хаалга руу зургаан мянга хүрэхгүй дайчдаа илгээсэн юм.

Тэд цаг үргэлж довтолгооныг хүлээн удаан урагшилж байв. Толгойн сэргийлэх, тагнуул гаргах ямар ч хэрэгцээ байхгүй тул эгнээгээ аль болохоор нягт барьж явлаа. Моргулийн хөндийгөөс гарснаас хойш тав дахь өдөр дуусч байлаа. Дайчид сүүлчийн удаа буудаллаж, ховорхон олдох хатсан үндэс, бутны иш төдийхнөөр түүдэг гал асаав. Хэний ч нойр хүрсэнгүй, эргэн тойронд дөнгөж үзэгдэх төдий үл мэдэгдэх хачин араатнууд шиншлэн тойрч, чоно улилдана. Салхи намдаж, агаар дахиад л бүгчим боллоо. Цэлмэг шөнө байсан бөгөөд шинэ сар гарснаас хойш дөрөв хоносон боловч шинэ сарыг утаан хөшиг хааж байв. Газар шатаж байгаа юм шиг энд тэндгүй утаа.

Сэрүүсч эхлэв. Үүрээр умардын ширүүн салхи үлээлээ. Шөнийн тагнуулууд алга болж, хоосон тал урьдынхаасаа ч илүү нам гүм болов. Хойт талд өмхий үнэртэй нүхнүүдээс бөөн бөөн үнс, хайрга, хагас шатсан нүүрс, шатаасан шавар гээд л Мордороос гарсан хаягдал зөндөө хөлөрчээ. Өмнө талд Хар хаалганууд, тэдгээрийн хоорондын цамхгууд бүхий Кирит-Горгорын нүсэр сүрлэг хадан хясаанууд ойрхон сүглийж харагдав. Дайчид хуучин замаас хажуу тийш эргэж, тоо тоомшгүй олон тагнуулын соргог хараанаас дайжин Мораннон руу баруун хойноос нь орж ирэв. Энэ замаар Фродо орсон билээ.

Хар хаалганы нүсэр том нуман хаалган доорх ширмэн самбарууд нам хаалттай, хэрмийн шүдэт хананууд дээр юу ч алга. Эргэн тойрон анир чимээгүй ноёрхож байлаа. Дайчид цааш явах газаргүй мухарт тулж, үүрийн саарал гэгээн дунд, ямар ч хүчирхэг харвагчаар цөмлөх боломжгүй хүчирхэг хэрэм, цамхагуудын өмнө балмагдан зогслоо. Тэдний ямар ч дайралтыг цөөн тооны хамгаалагчид няцааж болохоор байсан бөгөөд Моранноны дэргэдэх ууланд тийм хүч шороон түмээрээ, хавцлуудад ч гэсэн орхуудаас хамаагүй аймшигтай тоо тоомшгүй олон дайсан нуугдаж байгаа нь эргэлзээгүй. Дайчид дээш харахад хар сүг сүүдрүүд Мордорын соёо цамхагт нисэн бууж, дээгүүр нь тэмээлзгэнэ шиг эргэлдэн тушаал хүлээж байгаа нь илэрхий. Гэвч Дайсан яагаад ч юм сатаараад байлаа.

Харин өрнөдийн дайчид хүссэн ч, хүсээгүй ч тоглолтоо эцэст нь хүртэл тоглох хэрэгтэй байлаа. Арагорн цэргээ шороо хайрга хоёроос бүтсэн хоёр том толгод дээр байрлуулав. Орхууд олон жилийн турш шороо хайрга асгасаар ийм уул бий болсон ажээ. Мордороос тэднийг маш өргөн бөгөөд гүн суваг зааглаж байв. Сувгийн ёроолд утаа уугисан өмхий намаг, цөөрөм байна. Цэргүүдээ байрлуулсны дараа удирдагчид херальдууд, бүрээчдээс бүрдсэн томоохон бүлэг дагуулан Хар хаалга руу зүглэв. Цувааны түрүүнд Гэндалф, түүний араас Арагорн, Элрондын хөвгүүд, Ристанийн Эомер, Имраиль нар явлаа. Мордорын дайсан бүх ард түмнүүдийн төлөөлөгчид хэлэлцээрийн гэрч байхын тулд Леголас, Гимли, Перегрин гурвыг ч дагуулав.

Тэд Мораннонд хүрч ирээд тугаа мандуулж, бүрээнүүдээ хүнгэнүүлэв. Херальдууд урагш гарч

ирээд.

- Хэлэлцээрт гараад ир! Харанхуй хязгаарын эзэн өөрөө гарч ир! Тэр Гондор руу зэрлэгээр довтолж, бусдын газрыг эзэлсэн. Гондорын эзэн хаан тэрнийг хийсэн нүглээ наманчилж, харанхуйн хаан ширээгээ үүрд орхихыг шаардаж байна. Гараад ир!

Хариу өгөлгүй зөндөө удав. Хаалганы цаанаас ямар ч чимээ гарсангүй. Саурон бүгдийг тооцоолсон бөгөөд, эхлээд хулгануудтай хатуу тоглох, дараа нь хулганы урхиа хумхихаар шийджээ. Удирдагчид буцахаар шийдэж байтал нам гүмийг эвдэн гэнэт асар том бөмбөрүүд уул нурах мэт нижигнэж, бүрээнүүд чих дөжиртөл цархиран цууриалж, хөл дорх хадан хөрс доржив. Эцэст нь хар хаалганы дундах хаалга чихран нээгдэж, Барад-Дурын элч нар гарч ирэв.

Тэднийг хар морьтой өндөр этгээд тэргүүлжээ. Морь ч гэж дээ, асар том, адууны дүрс хэлбэртэй мөртөө адуу гэхэд адуу биш, толгойных нь оронд адууны толгойтой төстэй гавлын яс байх бөгөөд ухархай, хамрын нүхнээс нь хүрэн улаан гал улалзах ажээ. Хар цув, өндөр хар дуулгатай тэр морьтон бол бөгжтөн биш, Барад-Дурын эзний даалгавар гүйцэтгэгч амьд хүн байв. Тэрний нэрийг хэн ч үлмэдэх бөгөөд өөрөө ч нэрээ мартсан, өөрийгөө “Сауроны зарлигийг тунхаглагч” гэдэг ажээ. Тэр бол “Хар нуменорчууд” хэмээн нэрлэгддэг хүн төрөлт урвагчдын удмын этгээд гэгддэг ажгуу. Тэд дундад газарт Сауроны бүрэн эзэрхийллийн үед ирсэн ба хар шидийн ухаанд татагдан түүнд урвасан гэдэг билээ. Хар эзэн Бөглүүд ойгоос Мордорт эргэж ирэхэд түүний даалгавар гүйцэтгэгч болжээ. Тэр эзэнтэйгээ адил хар санаа, харгис хэрцгийгээрээ түүнд таалагдаж, итгэлт зарц нарынх нь нэг болсон ба хар шидэд бага зэрэг суралцсан, орхууд түүнээс ухаангүй айдаг ажээ.

Тэрний араас хар хуяг дуулгатай арав гаруй хамгаалагчид үл анигч хүрэн нүд бүхий хар туг өргөжээ. Барууны удирдагчдаас хэдэн алхмын зайд ирээд Сауроны даалгавар гүйцэтгэгч мориноос бууж, тэднийг нэгд нэггүй харцаараа хэмжсэнээ учир зүггүй муухай хөхрөв.

- Ингэхэд танай сүргээс хэн чинь надтай ярих юм бэ дээ? Хэн нь миний үгийг ойлгох юм бэ? Ямар ч л гэсэн чи биш шүү! – хэмээн тэр Арагорн руу жигшиж зэвүүцсэн янзтай хараад - Эльфийн шилний хагархай олоод зүүчихэж, дээрмийн сүргээр өөрийгөө тойруулчихаад өөрийгөө хаан гэж бодож л дээ! Ямар ч дээрмийн сүргийн атаманы дагуулууд чинийхээс хамаагүй дээр!

Арагорн юу ч хариулсангүй, зөвхөн түүний нүд рүү шөвөгдөх мэт нэвг шувт ширтэхэд төдөлгүй Арагорн хөдлөх ч үгүй, зэвсэг рүүгээ гараа ч хөдөлгөөгүй байхад тэр толгой дээр нь илд далайсан юм шиг татвагасхийн ухрав.

- Би бол харольд бөгөөд элч, надад хүрч болохгүй! – гэж тэр хашгирав.

- Бидэнд тийм заншил байхгүй – гэж Гэндалф хариулаад – Манай элч нар ч ийм хачин бүдүүлэг хэлээр ярьдаггүй. Ерөнхийдөө хэн ч чамд заналхийлээгүй. Одоохондоо чи харольд бөгөөд элч учир биднээс айх хэрэггүй. Гэвч эзэн чинь ухаан орохгүй бол чамд болоод түүний бусад гар хөл бологчдод тун ч муу юм болно.

- Аах, тийм бий! Тэгэхлээр чи эдний гол хүн юм биз дээ, буурал сахал минь? Чи ертөнцөөр нэг хэрэн тэнэж, газар сайгүй төвөг удаж, шийтгэлээс чадамгай зайлдгийг чинь залхатлаа сонссон. Харин энд, ноён Гэндалф, чи хэрээсээ хэтэрлээ, агуу их Сауроны эсрэг санаатан юу болдгийг чи одоохон мэднэ. Надад дайны олз байна, чамд үзүүлэхийг надад даалгасан юм, хэрэв чи наашаа ойртох зүрх чинь хүрвэл юуны өмнө чамд үзүүлэх ёстой юм.

Тэр хамгаалагчдаа дохио өгөхөд хамгаалагч түүнд хар боодолтой юм өгөв. Даалгавар биелүүлэгч түүнийг задалж, эхлээд Сэмийн богино илд, дараа нь эльфийн товчтой мөнгөлөг саарал цув, эцэст нь Фродогийн мифрил хөө хуяг болон тэр гэхийн тэмдэггүй урагдсан хувцсыг үзүүлэхэд тэдний гайхаш, айдас хоёр зэрэг төрөв. Тэдний нүд харанхуйлж, эргэн тойронд юу ч үгүй болох шиг санагдаж, найдах юм юу ч үгүй болов. Имраиль вангийн ард зогсч байсан Пин гаслантай хашгираад урагш дайрав.

- Тайван бай! - гээд Гэндалф түүнийг барьж аван байранд нь зогсооход даалгавар биелүүлэгч эг маггүй хөхрөв.

- Чамд энэ муу одойнууд бүр сүргээрээ байдаг юм гээч! – гэж тэр дуу алдаад - Эд нар чамд ямар хэрэгтэйг мэдэхгүй юм, харин эднийг Мордор руу явуулахаас өөр тэнэг юм бодож олж чадсангүй юу чи? Гэхдээ хархны гөлчгийнд баярлалаа. Тэрэнд энэ юмнууд танил байх нь. Одоо чи ч гэсэн хуурах гэж оролдохгүй юм байгаа биз дээ.

- Надад хуурах хэрэгцээ алга - гэж Гэндалф тайван хариулаад. - Тийм ээ надад ч гэсэн энэ юмнууд танил, Сауроны гутамшигт ам хэл болсон чамайг бодвол би энэ юмнуудын талаар бүгдийг мэднэ. Харин чи энэ юмнуудыг яах гэж авчирсныг чинь л мэдэхгүй байна.

- Гномийн хөө хуяг, эльфийн цув, мөхөж сөнөсөн өрнөдийн кинжаал, Хоббитанийн тагнуул харх. Тийм ээ тийм, бид бүгдийг мэдэж байна! Тэртээ тэргүй мөхөх амьтдын хуйвалдаан ч илэрлээ. Ганцхан л юм мэдэх үлдлээ. Чи баригдсан тагнуулаа өндөр үнэлж байна уу? Хэрэв өндөр үнэлж байгаа бол богино ухаанаа хурдан ажиллуул. Саурон тагнуулуудад дургүй, тэрний хувь заяа одоо та нараас хамаарна.

Хэн ч түүнд хариу хэлсэнгүй, тэр ч тэдний сааралтсан царай, айдас дүүрсэн нүдийг хараад байгаа оносоноо мэдэрч дахин харжигнатал хөхрөв.

- Харж байна аа! Та нар тэрнийгээ их өндөр үнэлдэг юм байна. Эсвэл чи тэрэнд маш чухал даалгавар өгсөн юм уу? Даалгаврыг чинь тэр биелүүлээгүй. Одоо тэрнийг олон жилийн төгсгөлгүй тамлалт хүлээж байгаа. Бид Агуу цамхгийнхаа дотор сайн тамлаж чаддаг юм шүү. Удаан, аймшигтай, тарчлаан тамладаг юм. Эсвэл тамлахаа болиод дотрыг нь гадагш нь эргүүлээд чамд үзүүлэх үү, тэгвэл чи юу хийснээ мэдэх болно. Тийм ээ, хэрэв чи миний эзний болзлыг зөвшөөрөхгүй бол яг тийм л юм болно.

- Болзлоо хэлээтэх - гэж Гэндалф тайван хэлсэн боловч түүний царайд шаналан тодорч, эцсийн эцэст хувь заяаны өмнө нугарсан эртний бөгтөр өвгөн болсон шиг дэргэд нь байгаа хүмүүст харагдаж байлаа. Тэр ямар ч болзлыг хүлээж авна гэдэгт тэдний хэн ч эргэлзэхгүй байв.

- Ийм болзол байна – гэж Сауроны элч тэднийг доогтой инээн тойруулж хараад - Гондор болон түүний мэхлэгдсэн холбоотнууд агуу Сауроны өөдөөс хэзээ ч зэвсэг өргөхгүй, өргөх тухай бодох ч үгүй гэж тангараглаад, өрөвдмөөр өчүүхэн сүргээ авч Андуины цаана гар. Андуинаас зүүн тийш бүх газар одооноос эхлээд үеийн үед Сауроны мэдлийнх. Манант уул, Ристанийн хаалга хүртэлх баруун эргийн оршин суугчид Мордорын албатууд болж, зэвсэг зүүхгүй, гэвч өөр өөрийн ажлаа хийхийг зөвшөөрнө. Тэд зөвхөн өөрсдийнхөө аймшиггүйгээр эвдсэн Изенгардыг сэргээн бариад Сауронд өгнө. Тэнд Саруманаас илүү найдвартай захирагчийг томилно.

Тэрний нүднээс санаа нь ил харагдаж байв. Тэр өөрөө захирагч болж өрнөдийн бүх орныг гартаа атгахыг хүсч байгаа нь илт. Ирээдүйн эзэн боолуудтайгаа ярьж байгаа бололтой.

Гэвч Гэндальф түүнийг тоосон шинжгүй.

- Та нар нэг зарцын амины төлөө дэндүү их юм гуйж байгаа юм биш үү? Танай эзэн түүний хариуд наанадаж арван том дайныг нэг ч тулалдаангүйгээр хожихыг хүсч байна! Гондорын талд бут ниргүүлснээсээ хойш тэр байлдаад хэрэггүй, наймаалцсан нь дээр гэж шийдсэн юм шиг байна. Хэрэв бид тэр боолын амийг ийм өндөр үнэллээ гэхэд эсэн бусын муу муухай арга мэх, итгэлийг эвддэгээрээ цууд гарсан Саурон биднийг мэхлэхгүй гэсэн баталгаа хаа байна? Олзлогдсон боолыг бидэнд авчирч өг! Тэгвэл ярилцъя.

Гэндальф үхлийн халз тулалдаанд дайснаа харж байгаа юм шиг амьсгал даран Сауроны элчийг цоо ширтэхэд тэр хоромхон зуурт барьц алдах шиг харагдсанаа дахин жигшүүртэй хөхрөв.

- Чи Сауроны элчид үл итгэн доромжилж яаж чадаж байна! – гэж тэр хашгираад - Чамд баталгаа хэрэгтэй байна уу? Саурон баталгаа өгдөггүй юм. Та нар түүний өршөөлийг эрж байна уу? Тэгвэл эхлээд өршөөл эдлэх эрхээ ав. Түүний бүх болзлыг биелүүл, тэгэхгүй бол юу ч авахгүй!

- Гуйж авахгүй, гуядаж авна! - гээд Гэндальф нөмрөгөө сөхөхөд – түүний илдний ир бүрэнхийд гялсхийв. Тэр гараа өргөхөд хар элч арагш ухарлаа. Гэндальф урагш нэг алхангуутаа түүний гараас хөө хуяг, цув, илдийг булааж аваад

- Эдгээрийг бид сайн андынхаа дурсгал болгон авч байна! – гэж зарлаад – Харин чиний нөхцлийн тухайд бол бид хүлээж авахгүй. Тонилцгоо, хэлэх бүхнээ хэллээ, одоо чи херальд ч биш, элч ч биш. Дахиад нэг үг хэлье. Чи үхнэ. Бид худалч үхээр Саурон юм уу, тэрний гутамшигт боолтой хий дэмий чалчих гэж энд ирээгүй. Тонилцгоо!

Мордорын элч дахиад инээсэнгүй. Нүүр нь хачин муруйж, тэр үсрэхээр биеэ хурааж байгаа нь хамар дундуур нь галт шилбүүрээр ороолгосон араатан шиг харагдав. Хорсол заналдаа шатаж, амаар нь хөөс цахарч, галзуу хилэнгээ дарснаас хоолой нь хоржигнож байв. Гэвч тэр өмнө нь зогсч байгаа дайснуудынхаа хатуу ширүүн царай, хайр найргүй нүдийг хараад айдас нь хилэнгээ дарав. Тэр нэгэнтээ чанга хашгираад мангас шиг аймаар мориндоо мордож эргэхэд мордорын элч нар араас нь гүйж Кирит-Горгор руугаа оров. Тэд гүйж байхдаа бүрээ үлээсэн нь болзолт дохио бололтой. Тэднийг хаалгандаа гүйж хүрээгүй байхад Саурон

хулганы урхиа татлаа.

Үй олон бөмбөр нижигнэж, энд тэндгүй гал дүрэлзэв. Хар хаалганы нүсэр том самбарууд цэлийтэл нээгдэж, Мордорын цэрэг тогтоож болшгүй төмөр үер болон зад тавилаа.

Гэндальф болон бусад удирдагчид мориндоо үсрэн мордож, өөрийнхөн рүүгээ давхихад араас нь хорсож занасан инээд, орилооноор үдэв. Алсын цамхгийн ард, Эред-Литуин харанхуй уулын цаана нуугдаж байсан вастакуудын газар бүрхсэн хар арми тоос татуулж, чих дөжиртөл хашгиралдсаар нөмрөн орж ирлээ. Моранноны хоёр талын уулсаас үй түмэн орхууд уул нурах мэт бууж ирлээ. Удалгүй дайчдын байрласан хоёр саарал уул давалгаалж буй далайн дундах арал шиг болов. Дайсны хүч өрнөдийн дайчдаас хэдэн арав дахин олон байв. Саурон олзоо төмөр эрүүгээр үмхэж авлаа.

Арагорн аль болохоор хурдан ажиллалаа. Гэндальф тэр хоёрын байгаа уулан дээр ер бусын бөгөөд бардам туг – долоон одоор хүрээлүүлсэн Цагаан модтой туг дэрвэж байв. Нөгөө уулан дээр нь Ристанийн Цагаан морьт туг, Дол-Амротын мөнгөн хун хөлөгт тугтай зэрэгцэн дэрвэнэ. Хоёр уулыг дайчид хана хэрэм мэт тойрон хамгаалж, жадны үзүүр, илдийн ир нэвтэрч болшгүй ширэнгэ мэт хүрээлжээ. Тэрхүү хүрээний гадна талд хамгийн эхний цохилтыг өөр дээрээ хүлээн авч, хамгийн хүчтэй довтолгоог няцаахын тулд баатар дайчин вангууд зогсчээ. Зүүн талд Элрондын хөвгүүд дунаданчуудын хамт, баруун талд Имраиль ван, Дол-Амротын хүчирхэг баатар вангууд болон Цагаан цамхгийн хамгаалагчид зогсчээ.

Өрнийн салхи үлээж, эвэр бүрээнүүд хүнгэнэж, мэргэн сумнууд исгэрч байсан ч өмнөөс мандсан нарыг өмхий утаа халхалж, нар тэр утаан мананд бүүдгэрэн, ертөнцийн төгсгөлийг зарлан жаргаж байгаа мэт харагдана. Тэрхүү утаан манан дундаас хар сүг сүүдрүүд шумбан гарч ирэхэд тэдгээрийн зүрх чичрүүлж, амь тэмцүүлсэн орилоон үхлийн аймшиг төрүүлж, сүүлчийн найдварыг бөхөөж байлаа.

Пин, Гэндальф Фродог мөнхийн тамлагаанд орхиж байгааг сонсоод ухаан алдах шахсан боловч одоо ухаан нь бага зэрэг сэргэж, эхний эгнээнд Берегондын дэргэд, Имраилийн баатар вангуудын хамт зогсч байлаа. Амьдрал түүнийг залхаасан тул тэр аль болохоор хурдан алаад өгөөсэй гэж хүсч байв.

- Мерри надтай хамт байгаагүй нь харамсалтай – хэмээн тэр ойртож байгаа дайснуудыг хараад өөрийнхөө дууг сонсов. Дайсан ойртож ирсэн учир тэр бодлоо түргэлүүлж. “Тийм юм байна, хөөрхий Денэтор тийм ч буруу юм хэлээгүй юм байна. Би нэгэнт л үхэхээс хойш Мерритэй хамт үхсэн нь дээр байжээ. Гэтэл одоо өөр өөр газарт үхдэг юм байж, чамд хөнгөн үхлийг ерөөе дөө. За за, одоо гутамшиг бололгүй нэр төртэй үхье”

Тэгээд илдээ сугалж, түүн дээрх улаан, шаргал зураасуудын угалзалсан хэлхээг харав. Илдийн ирэн дээр нуменорын рун бичиг галт хэлхээ болон тодорлоо. “Яг энэ удаад л хэрэглэх гэж давгаж дээ, тэр муу элчийг нь даанч цавчиж болохгүй байлаа – ээ дээ, хэрвээ цавчаад хаячихсан бол Мерри бид хоёр гавьяагаараа бараг л тэнцэх байлаа даа. За яахав, энэ хар адгууснуудаас ядаж ганцыг цавчина даа. Гэгээн нар, ногоон зүлгээ дахиад харахгүй нь харамсалтай!” – хэмээн бодож амжив.

Тэгтэл ч түрүүчийн дайснууд тулаад ирлээ. Орхууд хоёр уулын өмнөх балчигт сувагт шигдэнгүүтээ суман мөндөр буулгав. Тэдний дундуур унасныг нь гишиглэн араатан мэт архирсаар Горгоротын уулын троллууд, хүмүүсээс ч өндөр, бахим чийрэг, төрөлхийн юм уу, хиймэл юм уу, бүү мэд матрынх шиг хайрсан хуягтай, дугариг хар бамбайтай, махир урт гартаа лужир том лантуу барьсан аймшигт амьтад дайран орж ирэв. Намаг балчиг тэдэнд юу ч биш байсан тул шууд л тэргүүн эгнээний гондорчууд руу урхиран дайрч, зөөлөн төмөр давгаж байгаа юм шиг дуулга, гавлыг бяц бяц цохин, бамбайнуудыг буталж, гар хөлийг тас тас хяргаж эхлэв. Аймшигт цохилт Берегондыг унагаж, нүсэр том толгойлогч тролль түүний дээрээс бөхийн махир урт хумст сарвуугаа сунгав. Энэ галзуу араатангууд унасан дайсныхаа багалзуурыг ёс юм шиг тасалдаг байв.

Пин тэрний доороос илдээрээ бүлж орхилоо. Эртний хээт илд тэр араатны хайрсан хуягийг нэвгэлж, гэдсэнд нь гүн орлоо. Өтгөн хар цус олгойдон тролль гуйвсхийснээ Пиний дээрээс хадан хясаа мэт дарж унав. Өмхий үнэрт шингэнд хахаж цацан, тэсвэрлэшгүй өвдөлтөөс ухаан алдахдаа Пин. “За, бүх юм тун тааруухан төгслөө дөө” хэмээн бодож амжив. Хачирхалтай нь, энэ бодол хөгжилтэй байв. Айдас, зовлон гуниг алга боллоо. Үхлийн өмнөх харанхуйд аль эрт мартагдсан өөр ертөнцөөс ирж байгаа юм шиг.

- Бүргэдүүд! Бүргэдүүд нисч ирлээ! – гэсэн дуу сонсдов.

Ухаан тавих агшинд. “Бильбо! Аа, нээрэн тийм, түүний үлгэр их эртний үлгэр шүү дээ, харин энэ бол миний үлгэр, гэхдээ миний үлгэр ингээд дууслаа. Баяртай!” – гэсэн бодол зурсхийгээд гүн харанхуй түүнийг залгив.

Бүлэг 11

Даваан дээрх цамхаг

Сэм арайхийн хөл дээрээ боссон боловч хаана байгаагаа яагаад ч санахгүй байв. Дараа нь гэнэт санаад уй гашуудаа уйлах шахав. Нээрэн тийм л дээ, нүдгүй харанхуйд, цайзын дэргэдэх хясааны ёроолд, орхуудын бэхлэлтийн хаалттай хүрэл хаалганы дэргэд шүү дээ. Улайран тулалдсандаа хальтирч унасан байх, харин хичнээн удаан хэвтсэнээ мэдэх юм алга. Тэгэхэд тэр тулаанд халуурч, хүрээд ирцгээ муусайн бузрууд аа, хичнээн олноороо бол төчнөөн сайн гэж байсан бол одоо даарч бээрэн, чичирч байв. Тэгээд хэрэмний хаалган дээр очиж чихээ наан чагнав.

Алсаас орхуудын шуугиан сонсогдох шиг болсноо чимээгүй болж, эргэн тойронд нам жим боллоо. Толгой нь маш их өвдөж, нүдний өмнүүр галт тоос гялалзах шиг болоход тэр толгойгоо сэгсрэв. Одоо яах вэ гэдгээ бодох хэрэгтэй байлаа. Бодоод бодоод яах билээ, цайзын хаалга хаалттай, нэвтрэх арга байхгүй. Нэгэн цагт нээх байх л даа мэдээж, гэтэл хүлээх цаг байдаггүй, цаг мөч бүр тооцоотой. Тэр юу хийх ёстойгоо мэдэж байлаа. Болж өгвөл эзнээ аварна, болохгүй бол өөрөө үхнэ.

- Үхэх ч яахав, тэрэн шиг амархан юм алга – хэмээн тэр өөртөө гунигтай хэлээд Терн илдээ хуйлж, хүрэл хаалганаас холдов.

Тэр харанхуй хонгилоор удаан гэгч буцаж гэлдрэв. Эльфийн аягаа гэрэлтүүлэхээс болгоомжилж байсан ба Уулзвараас гарснаас хойш юу юу болсныг санах гэж байдгаараа оролдож явлаа. Хичнээн хугацаа өнгөрсөн бэ? Хэн тэрийг мэдэх вэ дээ, хэрэв өнөөдөр, өнөөдөр л биш бол маргааш байж таарна, өдөр хоногийн тоо тэртэй тэргүй алдсан. Ийм харанхуйд аль нь өчигдөр, аль нь өнөөдрийг яаж ялгах юм бэ, өдөр сар байтугай өөрийгөө алдана.

- Магад, тэд нар бид хоёрыг санаж байгаа даа – гэж тэр өөртөө хэлээд

- Өөрсдөө яаж яваа бол доо? Хаана? Тэнд биш биз дээ? – гээд тэр хандсан зүг рүүгээ гараа дохив. Тэр нь өмнө зүг байлаа, тэр Шелобын ичээнээс гараад өмнө зүг рүү явсан болохоос баруун зүг рүү яваагүй билээ. Харин энэ үед баруун зүгт хоббитийн тооллоор гуравдугаар сарын арван дөрөв дэх өдөр байсан бөгөөд Арагорн хар флотоо Пеларгираас хөдөлгөж, Мерри мустангримчүүдтэй Чулуубутлахын хөндийд давхиж, Минас-Тиритэд түймэр дүрэлзэж, Пин Денэторын ухаангүй харцнаас айж байсан билээ. Тэд хичнээн их аюул, зовлон дунд байсан ч Фродо, Сэм хоёрыг мартхааргүй, үргэлж тэр хоёрыг бодож байсан юм. Бодоод бодоод туслах арга байхгүй байлаа, одоо ч гэсэн тэдний хэн нь ч Хэмбриджийн хүү Сэммиумд тусалж чадахгүй, тэр гав ганцаараа байна.

Тэр чулуун хаалган дээр буцаж ирээд хичнээн хайсан ч цоож цуурга, түгжээ олдсонгүй, дахиад л хаалга, хана хоёрын хоорондох завсраар шургаж гараад Шелобын ичээнээс гарахаар тэмтчин урагшлав. Түүний тасалсан аалзны тор хүйтэн салхинд хийсч, өмхий үнэртэй бүгчим газраас гарсан Сэмд хүйтэн боловч цэвэрхэн санагдав. Тэр гадагш болгоомжтой

мөлхөж гарлаа.

Аймаар нам гүм байв. Бүрхэг өдрийн орой шиг харанхуйвтар байлаа. Доороосоо бүдэг хүрэн галаар будагдсан нүсэр утаан үүлс Мордорын дээгүүр бөөгнөрөөд баруун зүг рүү мөлхөнө.

Сэм орхуудын цамхаг руу хартал нарийхан цонхнуудад нь гэнэт жижигхэн улаан нүднүүд шиг гэрэл асав. “Дохио өгч байгаа юм байх даа” – гэж тэр бодтол уур хилэн, цөхрөл хоёрт дарагдсан айдас нь дахин сэргэв. Түүнд ганцхан зам байгаа нь илэрхий. Хараал идсэн энэ цамхаг руу орох гол хаалгыг л олох хэрэгтэй. Даанч өвдөг нь нугарч, чичрээд болдоггүй. Тэрбээр цамхгаас, хавцлын хадан эврүүдээс хараагаа салгаж, дуулгавар муутай хөлөө удаанаар зөөн гишгэсээр, өчүүхэн төдий чимээ болгоныг чагнаархан, хадан хясаануудын сүүдрүүдийг харсаар, Фродогийн хэвтэж байсан, одоо ч хүртэл Шелобын үнэр ханхалж байгаа тэр газрын хажуугаар, дараа нь дээш, бөгжийг зүүгээд Шагратын орхуудыг дэргэдүүрээ өнгөрүүлсэн тэр ирмэг хүртэл өгсөв.

Ухаант хоёр хөл нь цааш явахаас таггалзаж, тэр ямар ч гэсэн жаахан сууж бодохоор шийдэв. Тийм ээ, одоо тэр энэ ирмэгийг даваад л Мордорт орчихно, тэндээс эргэж буцах зам байхгүй. Яагаад ингэснээ өөрөө ч мэдсэнгүй бөгжийг гаргаж ирээд зүүчихэв. Шууд л ер бусын их хүнд ачаа дээрээс нь дарж, Мордорын зэвүүн нүд улаан дэргэд нь урьдахаасаа зуу дахин тод улалзаж, хар эзний харанхуйг нэвглэв.

Яг түрүүчийн удаагийнх шиг сонсгол хурцдан, хараа бүүдэгрэв. Хад асганууд мананд живэх мэт цайвартан алга болсон мөртөө, Шелобын гаслан ёолох дуу маш тод сонсогдож, яг дэргэд нь юм шиг улайран хашгиралдах, зэвсэг хангинах дуулдлаа. Тэр босон харайж, хавцалд чихээ наагаад, үзэгдэхгүй байгаадаа баярлалаа. Орхууд юу юугүй пижигнэн орж ирнэ гэж тэр бодов. Дараа нь дэмий айснаа ойлгов. Ердөө л түүний яг эгц өмнө ёрдойж байгаа цамхгийн дээд давхарт орхууд ердийнхөөсөө хавьгүй чанга хашгиралдаж байв.

Сэм толгойгоо сэгсрээд цаашид яах вэ гэдгээ дахин бодлоо. Тун ч олигтой юм болох шинжгүй. Орхууд бүр галзуурч, бүх тушаалыг нулмиж орхиод одоо Фродог тамлаж байгаа, аягүй бол хэдэн хэсэг тасдаад хаячихсан ч байж магадгүй шинжтэй болов. Дахиад жаахан чагнатал гэнэт ямар нэг найдвар сүүмэлзээд явчихлаа. Цамхагт хэрүүл зодоон болж байгаа нь илэрхий, орхууд хоорондоо хэмх нүдэлдэж байна. Шаграт, Горбаг хоёр ямар нэг юм булаалджээ. Өчүүхэн найдвар боловч Сэмд тэр нь хангалттай байв. Юу болохыг хэн мэдлээ, ямар нэг боломж гарах ч юм билүү? Юу ч боллоо гэсэн хамаагүй, Фродог гэх сэтгэл нь дийлж, тэр өөрийгөө ч мартаад:

- Ноён Фродо, эзэн минь, очлоо, очлоо! – гэж хашгирав.

Тэгээд зөрөг замаар гүйж ирмэг дээгүүр давлаа. Зөрөг баруун тийш эргээд, дараа нь эгц доошлов. Сэм Мордор руу орлоо.

Тэр аюул ойртож байгааг зөнгөөрөө мэдэрч бөгжийг сугалав, гэхдээ орчныг сайн харахын тулд л тайлжээ.

- Сайн харах хэрэгтэй, тэгэхгүй бол манан дунд төөрнө! – гэж тэр амандаа бувтнав.

Хатуу ширүүн, зовлонд идэгдсэн, тарчиг газар байлаа. Тэр Изгарын уулын хамгийн өндөр нэг ирмэг дээр зогсч байв, доор нь эгц өндөр хажуу, харанхуй хонхор байна. Хонхрын цаад талаар уул нь арай намхан бөгөөд хүрэн улаан галд туяарсан хар шүднүүд мэт хадан хясаанууд сэрийлцэнэ. Энэ бол хотын дотоод хэрэм буюу Моргвей байлаа. Түүний цаана, энд тэнд сүүмэлзэх галууд бүр харанхуй тэнгисийн цаана тэнгэрийн хаяа хүртэл хүрэнтэн, доод хэсгээрээ хүрэн улаан өнгөт хар угаан баганууд тэнгэрийг өрөмдөн босч, тэнгэрийн мандалд гараад нэгэн цул нүсэр хар үүл болж нийлээд хар тахалд идэгдсэн энэ хязгаарын дээрээс дарж байлаа.

Сэм Ородруин хэмээх Галт уул руу харав. Түүний шовх үзүүрт үнсэн өнгөт оргил тээр дээр сүмбэрлэн, бэл орчимд нь галан хөөрөг оргилж, хажуугийн гуу жалгануудаас шингэн галаар тургилан нэг хэсэг нь Барад-Дур руу урсан орж, бусад нь чулуурхаг тал руу мурилзан урсч очоод газар дороос гарч ирээд хөшсөн луунууд мэт царцаж байлаа. Мордорын чөтгөрийн дархны газрын хүрэн улаан галан хөөрөг баруун талаасаа буюу Эфель-Дуатын цаанаас харагдахгүй ч Сэмийн нүдийг сохлох дөхөж, Моргвейн хадан хясаанууд цусаар будагдсан юм шиг харагдана.

Сэм зүүн тийш эргэж, Кирит-Унголын цамхгийг түүний бүх далд хүчтэй нь хараад айн чичрэв. Изгарын дээрх эврүүд зөвхөн дээд үзүүр нь байсан бөгөөд зүүн талаасаа гурван давхар, цайзууд нь доод хэсэгтээ нүсэр том, дээшлэх тусмаа улам нарийссаар зүүн өмнө болон зүүн хойт зүг рүү харсан шүд болжээ. Тэр давхруудыг гайхалтай уран нарийн тавьжээ. Доод давхар болон Сэмийн хөл доор байгаа хоёр зуу орчим фут талбай өргөн зам руу харсан шүдэт ханаар хүрээлэгдсэн байв. Сэмийн зогсч байгаа нарийхан зөрөг шатлан уруудсаар цамхгийн хаалганы ойролцоох ханан доогуур орсон замтай нийлжээ.

Сэм цамхаг руу харж байгаад гэнэт энэ бэхлэлт эхэндээ Мордорт үйлчилж байгаагүй, харин түүний эсрэг байсныг ойлгов. Үнэн хэрэгтээ Сүүлчийн холбоо Сауроныг ялж, бүрэн устгагдаагүй дайсны үлдэгдлүүд харанхуй хязгаараар тэнэж байсан тэр эрт цагт гондорчууд энэ цайзыг барьжээ.

Гэвч Моранноны соён цамхагууд - Наркост, Каркост хоёрыг эзэлсэнтэй адилаар л энэ цамхгийг эзэлсэн байна. Бөгжтөнүүдийн толгойлогч хамгаалалтынхныг мэхлээд, олон зууны турш энэ цамхгийг эрхшээлдээ оруулжээ.

Саурон эргэж төрсний дараа энэ цамхаг улам ч хэрэгтэй болсон байна. Түүнд үнэнч зарц бараг байхгүй болсон, айдсаар хүлсэн боолуудыг Мордороос гаргаж болохгүй байсан. Хэрэв дайсан энд нууцаар нэвтрэхийг оролдвол Минас-Моргулыг тойрч гараад Шелобт харагдахгүй өнгөрнө, тэгвэл үл зүүрмэглэгч харуулууд түүнийг барина.

Хэдэн зуун сэрэмжит нүд, сонор чихний хажуугаар нэвтрэх боломжгүй, яагаад ч хаалгаар өнгөрөх аргагүй гэдэг нь Сэмд тодорхойгоос тодорхой байлаа. Нүдний цөцгийнөөсөө ч илүү хамгаалж байгаа тэр замаар хол явахгүй нь мэдээж байв. Хүрэн туяат харанхуйд хичнээн ч нуугдлаа гэсэн орхуудаас нуугдаж чадахгүй, тэд харанхуйд муурнаас ч илүү хардаг. Тэр нь ч яахав гэж бодоход Сэмд зугтаах юм уу, нуугдах хэрэгцээ байхгүй, хаалгаар л орох хэрэгтэй байлаа.

“Бөгж үү? Бөгж бол ямар ч дайснаас аюултай” гэж тэр бодлоо. Алсад хараалт уул нижигнэн хүрхэрч, Сэмийг бүр ч хүнд байдалд оруулж байлаа.

Нэгэн цагт бөгжийг давтсан энэ хөөргөн уулын дэргэд бөгжний нууц хүч улам ихэсч, түүнийг эзэмдэхийн тулд агуу их хүч хэрэгтэй болох нь илэрхий байв. Сэм бөгжинд гар хүрсэнгүй, тэр хүзүүнд нь зүүлттэй байж л байна, гэвч тэр өөрөө өсч хүчирхэгжин, түүний агуу хүчирхэг чадал Мордорт орж ирж байгаа юм шиг санагдав. Түүний өмнө хуурамч сонголт босч ирлээ. Нэг бол бөгжнөөс татгалзаж, өөрийгөө тамын зовлонд унагах, эсвэл бөгжний эзэмшигч болж, харанхуйн гүн дэх хар цамхагт суугаа тэр хар эзэнг өдөн дуудах. Бөгж түүнийг урин дуудаж, урам зоригийг нь хурцлан, саруул ухааныг нь самууруулж байлаа. Мөрөөдөл түүнийг эзэмдэв. Тэр өөрөө - баатруудын баатар Зоригт Сэммиум гал дөл цацарсан илдээ өргөн харанхуй талаар Барад-Дур руу сүр хүчин төгс алхаж явна, түүнийг дуудсан даруйд тал талаас нь үй олон дайчид шуугин ирж байна. Тэгээд хар үүлс алга болж, хурц нар мандан, Горгорот үр жимсээр дүүрэн цэцэрлэг болон хувирч байна. Тэр зөвхөн бөгжийг зүүгээд л “Энэ минийх” гэж хэлэнгүүт энэ мөрөөдөл биелэх юм шиг.

Энэ хүнд сорилтын үед түүнд эзэндээ үнэнч зүтгэх сэтгэл нь тус боллоо. Түүнээс гадна тэр хоббитийн ердийн эрүүл саруул ухаанаар ийм хүнд ачааг би даахгүй гэж оюун ухааныхаа гүнд багтай мэдэж байлаа. Надад миний цэцэрлэг байхад л хангалттай, түүнийгээ бүхэл бүтэн хаант улс болгох ямар хэрэг байна. Надад хоёр гар минь байна, бусдын гараар гал хамаад яах билээ гэж тэр бодов.

- Би юунд өөрөө өөрийнхөө толгойг эргүүлэх гээд байгаа юм бэ? – хэмээн тэр бувтнаад: - Тэр намайг үзэнгүүтээ хашгирч ч амжаагүй байхад минь базаад авна. Тэр намайг энд, Мордорт бөгжийг зүүх гэж бодож байгааг шууд л харна. Нэг үгээр бол, илдийг яаж ч шидсэн ирээрээ бууна. Мөн хясаа аа, яг л үзэгдэхгүй байх хэрэгтэй болонгуут бөгжинд гар хүрч болохгүй байдаг. Энэ ч яахав гэж бодоход цаашдаа надад улам л гай тарина, мөн ч бэрх ачаа юм даа! Одоо яадаг юм билээ дээ?

Энэ асуултыг Сэм зүгээр л өөрөөсөө асуусан юм. Хаалга руу хурдан явах хэрэгтэй гэдгээ тэр мэдэж байлаа. Тэгээд хий үзэгдлийг хөөн зайлуулах гэсэн мэт мөрөө хавчиж, толгойгоо сэгсрээд аажуухан уруудав. Алхах тусам тэр улам л жижигрээд байх мэт. Зуугаад алхам яваад тэр дахин үнхэлцэг нь хагартлаа айсан бяцхан хоббит болж орхив. Цамхгаас ямар ч бөгжний хэрэггүйгээр орилолдох, зэвсэг хангинах сонсдож байсан бөгөөд цамхагт төдийгүй, хэрэм дотор ч нүдэлдэж байгаа нь сонсогдож байв.

Сэм замын хагасыг туулж, харанхуй хаалганаас хүрэн туяа туссан зам дээр бууж иртэл хоёр орх гүйн гарч ирэв. Аз болоход тэр хоёр Сэм рүү гүйж ирээгүй бололтой, хол ч явсангүй тэр дороо нам ойчоод өгөв. Тэднийг хэрэмнээс юм уу, шагайвчаас харвасан бололтой. Сэм зүүн мөрөөрөө хана түшин болгоомжтой урагшлав. Дээшээ өлийж хартал юун авирахтай манатай, яагаад ч бүтэшгүй. Гучин фут толийсон гилгэр чулуу – нэг ч ан цав, нэг ч овгор товгор алга. Хаалгаар л орохоос өөр замгүй.

Тэр хаалга руу гэтэж явахдаа цамхаг дотор Шагратын дэргэд хэдэн орх байгаа бол гэж бодож явав. Бөгтөртэй наяд орх байсан бөгөөд Шаграт бүгдийг цамхгаас гаргасангүй. Тэд мэдээж хэрэг, олзноос болж, өөрөөр хэлбэл Фродог булаалдан эвдрэлцжээ.

Сэм дороо зогсов. Ойлгомжтой байна, тэр бараг өөрийн нүдээр харсан юм шиг ойлгомжтой байна. Мифрил хөө хуяг! Мэдээж хэрэг, Фродогийн хувцсыг тайлсан, хөө хуягийг харцгаасан, Бөгтөр түрүүлж тэрийг авсан, яагаад гэвэл тэд түрүүлж олсон шүү дээ! Тэгэхлээр Фродогийн амь хутганы ирэн дээр байна, түүнийг зөвхөн Хар цамхгаас ирсэн тушаал л хамгаалж байна, хэрэв орхууд буруу сонсвол...

- Чи муу хэнд ч хэрэггүй нялцгай нус минь! – гэж Сэм өөртөө хэлээд: - Хурдан гүй! – гэж өөртөө тушаалаа.

Тэрбээр Терн илдээ сугалаад нээлттэй хаалга руу ухасхийн хурдлав. Гэвч нуман хаалган доогуур орохын даваан дээр түүнийг ямар нэг юм саатуулав. Шелобын аалзны шүлс шиг, тэгсэн мөртөө үзэгдэхгүй юм. Хаалга цэлийтэл нээлттэй байхад орж болдоггүй. Сэм хаалганы хоёр талаар хараад сүүдэрт хадан мануухайнууд байхыг үзэв. Тэд бол цөмөөрөө гурван салаа биетэй, гурван толгойтой, урагшаа хойшоо, хаалганы эсрэг тал руу харсан бөгөөд толгой нь тэмээлзгэний толгой шиг, урт махир хумст сарвуугаа өвдөг дээрээ тавьсан хөдөлгөөнгүй чулуун хөшөөнүүд боловч туйлын соргог, хорсол заналтай хардаг, дайснаа таньдаг хөшөөнүүд бөлгөө. Үзэгддэг, үзэгддэггүй хэн ч тэдэнд харагдахгүйгээр хажуугаар нь өнгөрч чадахгүй. Тэд оруулахыгаа оруулдаг оруулахгүйгээ оруулдаггүй.

Сэм байдаг хүчээрээ ухасхийтэл тас түрүүлгээ харан унаж, нүүрээ шалбалав. Тэгээд толгойд нь өөр юу ч ороогүй учир их зориг гаргаж, өврөөсөө Галадриэлийн аягыг гаргаж ирээд толгой дээрээ өргөв. Аяганы гэрэл мөнгөлөг өнгөөр дүрэлзэн асч, харанхуй нуман хаалгыг гэрэлтүүлэхэд харанхуй дотроос огиудас хүрэм муухай дүрээрээ гэрэлд ил гарсан харуулууд чулуу мэт хөшиж орхив. Тэдний чулуун нүд үзэн ядалтаар дүүрэн байлаа. Сэм тэдний айдсыг арьс махаараа мэдэрлээ. Тэгээд аягаа өвөртлөөд, тэдний хажуугаар гүйн гарахад ард нь төмөр түгжээ түгжигдэх нь сонсогдов. Харуулууд улам ч сонор сэрэмжтэй болж байгаа нь илт, зэрлэг чангаар хашгиралдахад хэрмийн өндөр хананууд цууриалан дамжууллаа. Тээр дээр түгшүүрийн хонх дүнгэнэлээ.

- Болчихлоо! – гэж Сэм санаа амар хэлээд:

- Хөөе, та нар хаана байна, наашаа хүрээд ир! Эльфийн илд далайсан аварга том эльф баатар энд ирчихлээ гэж тэр Шагратдаа хэл! – гэж хашгирав. Хариу байдаггүй. Сэм хурц цэнхэр гэрэл цацруулсан Терн илдээ барьж, урагш тэмүүлэв. Хашаанд. Яг дэргэд нь нуруундаа хутга зоолттой хоёр харваачийн хүүр хэвтэнэ. Сум зоолттой, тасар цавчуулсан, хоолойгоо боолгосон, хазуулсан хүүрнүүд бие биетэйгээ зууралдсан хэвээрээ хөшчээ. Халтирхай чулуун шалан дээгүүр хар хүрэн цус нөжрөн тунасан байв.

Зарим хүүр нь хүрэн нүдний дүрстэй, зарим нь сарны дүрстэй байв. Цамхгийн ёроол дахь том хаалга хагас нээлттэй, босгон дээр нь нүсэр том орх үхсэн хэвтэнэ. Сэм түүний дээгүүр харайж, ийш тийшээ харсаар дотогш оров. Ханан дахь бамбаруудын гэрэл өргөн хонгилыг бүдэг бадаг гэрэлтүүлж байлаа. Хоёр талаар олон хаалга, нүх онгойн харлаж, хоёр гурван хүүрнээс өөр юу ч байсангүй. Сэм орхуудын удирдагчдын ярианаас Фродо ямар ч гэсэн энд байгааг мэдсэн тул амьд, үхсэн аль нь ч бай олох учиртай, гэхдээ “Хамгийн дээд давхарт, нууц нүх” – нээс олох хэрэгтэй гэж ойлгосон ч бүтэн өдөр эрж байж олох байв.

- Нөгөө талд л байгаа юм шиг байна, цамхгийг ууланд налууулж хөндлөн барьсан байна. За за, урагшаа л яваад байя, харанхуй руу орж юугаа хийх вэ - гэж Сэм өөртөө бувтнав.

Тэр хонгилоор хөлөө арай ядан зөөж, удаан явж байлаа. Тэр дахиад л маш их айж эхлэв. Нам гүм орчныг зөвхөн түүний болоомжтой алхах чимээ эвдэж, чулуун шалан дээгүүр аварга том сарвуугаар алгадаж байх мэт сонсогдоно. Үхдлүүд, хоосон орон зай, харанхуй хаалга бүхний цаана нуугдаж байгаа үхэл, хүйтэн саарал өнгөт хананууд, өөрийг нь отож байгаа аймшигт мангасууд гээд айх, болгоомжлох юм зөндөө олон байв. Ингэж айж чичирч явснаас алалдсан нь дээр, нэг хоёр орх над руу дайраад ирээсэй гэж тэр бодож байв. Тэгээд энэ аймшигт цамхгийн хаа нэгтээ шархадсан, хүлэгдсэн, эсвэл алагдсан хэвтэж байгаа Фродогийн тухай бодохыг хичээлээ. Тэгээд хором ч зогсолгүй урагшилсаар байв.

Бамбарууд байхгүй болж, Сэм цамхгийн арын хаалга бололтой хамгийн сүүлчийн хаалганд хүрэв. Түүний дээрээс гэнэт амь тэмцэн бархирах дуун хадав. Зогсоод чагнатал хэн нэгэн шатаар гүйж байгаа нь сонсогдлоо. Тэр гараа захирах зориг хүрсэнгүй, өөрийн эрхгүй бөгжний гинжнээс атгалаа. Гэвч Сэмийг бөгжөө зүүж амжаагүй байтал баруун талаас нэг орх гарч ирээд шууд өөр рүү нь харайж ирэв. Тэр зургаан алхмын цаана хүрч ирээд гэнэт Сэмийг харж, дээш өлийхөд нь Сэм түүний амьсгаа, бүлтийсэн нүдийг харав. Орх түүний өмнө айсандаа илд барьсан гар нь чичрэн зогссоноо татгасхийж, зэрлэгээр хашгираад буцаж гүйв. Сэм том нохойг санамсаргүй айлгасан гөлөг шиг баярлан зориг орж, түүний араас хашгиран гүйв:

- Аа, чи муу эльф баатрыг харсан уу! Тэр чинь би байна. Хамгийн дээд давхарт гарах замыг заагаад өг, тэгэхгүй бол арьсыг чинь хуулна шүү!

Гэвч цатгалан, шаламгай орх гэртээ байгаа, өлсгөлөн, ядарч туйлдсан Сэм алхам тутамдаа бүдэрч, амьсгаа нь давхцаж байсан тул орхыг гүйцсэнгүй.

Гэсэн ч Сэм дээш өгслөө. Зөв замаар явж байгаагаа мэдэрсэн тул түүнд хүч нэмэгдэж байв.

- За за, эд нар Тернийг хараад л надаас айгаад байх юм бол би эднийг аргалж дөнгөх байх. Шаграт, Горбаг хоёр болон тэдний цэргүүд миний төлөө сайн ажилласан шиг байна. Саяны аймхай новшоос өөр амьд юм энд алга юм шиг байна – гэж өөртөө хэлэв. Ингэж хэлэнгүүтээ тэр духаараа чулуун хана мөргөсөн юм шиг зогтусав. Амьд амьтан байхгүй биш бололтой, хэн нэгэн орь дуу тавин хашгирах нь сонсогдох шиг боллоо.

- Фродо, Фродо! Эзэн минь! Эд нар таныг алчихсан бол би яах юм бэ? Явж л байна, яасан ч гэсэн яваад л байна, хожимдохгүй л юмсан! – гэж хашгирлаа. Шат улам л дээшээ өгсч, эргүүлэг бүр дээр байгаа бамбар дээд давхруудыг гэрэлтүүлж байв.

Сэм шатны гишгүүрүүдийг тоолж, хоёр зуу гаргаад тоо алдав. Дээрээс ямар нэг дуу хоолой сонсогдох шиг болсон тул тэр аяархан мярааж явлаа. Ямар ч гэсэн ганц орх биш бололтой, хоорондоо ярилцаж байна. Хөл нь хөшиж, амьсгалах ч тэнхэлгүй болох үед шатны төгсгөлд хүрэв. Тэр зогсоод эргэн тойрноо харлаа. Тэгээд гуравдугаар давхарт, жараад тохой өргөн дугариг талбай дээр гарч ирснээ мэдэв. Зүүн талд, тэртээ алсад Мордорын харанхуй цөл, түүний цаана галт уул Ородруин дүрэлзэж харагдав. Баруун тийш харвал харуулын цамхгийн

дээрх хашаа шиг юман дотор цонхны гэрэл сүүмэлзэж байна. Гучин алхмын цаана нээлтэй хаалга харанхуй дундаас гэрэлтэж, дотроос нь орхуудын яриа сонсогдож байв. Сэм талбайг тойруулан харвал энд том зодоон болсон нь илт байв. Энд тэндгүй гулдайсан хүүр, тас цавчигдсан толгой, гар, хөл хөглөрч байв. Хүүрийн самхай үнэр агаарт тунарчээ. Гэнэт хэн нэгэн муухай хашгирч, хэн нэгнийг цохиод авах нь дуулдахад Сэм эргээд шат руу ухасхийв. Тэр бол Шагратын дээрэнгүй, сөөнгө хоолой байлаа:

- Чи юу болчихоов, Снага, явахгүй гэнэ үү? Чамайг даа, муу баасыг! Би шархадсан бол чи намайг яаж ч болно гэж бодоо юу? Наашаа хүрээд ир, би Радбугийн нүдийг бүлтэлсэн шигээ бүлтлээд өгье, яаж орилж байхыг нь сонсоо биз дээ, чи? Одоо залуус хүрээд ирнэ, тэгээд би чамайг төхөөрч, Шелобыг хооллоно доо!

- Чамайг үхэхээс өмнө хэн ч амжиж ирэхгүй. Чамд би хоёр дахиж хэллээ. Моргулийн дээрэмчид хаалгыг хаасан, манайхнаас нэг нь ч амьд гараагүй. Лагдуф, Музгаш хоёр нэвгэрсэн боловч хоёуланг нь харвачихсан. Би цонхоор харсан юм чинь. Бүгд үхсэн.

- Тэгвэл чи явах болно доо. Би тэртэй тэргүй энд байх ёстой. Горбаг муу хүүр намайг шархдуулсан, тэр хүүр хар нүхэнд ялзрах болтугай – гээд Шаграт удтал баахан хараан зүхснээ:

- Би тэрнийг боомилж байхад тэр намайг хутгаар дүрж амжсан юм. Хурдан яв, Лугбурзад бүгдийг илтгэ, тэгэхгүй бол чи ч дуусна, би ч дуусна!

- Би явахгүй, чиний дарга марга надад ёстой яршиг л байна. Хол очиж хуц! Хутгаа шүүрсний хэрэггүй, гэдсэндээ сум зоолгоно шүү. Дарга байдаг чинь ч өнгөрсөн, чамайг юу хийснийг чинь тэнд мэдэж л таарна. Моргулийн хүүрнүүдийг хядсан чинь зөв, гэхдээ Горбаг та хоёр олзоо булаалдаж алалдсан шүү дээ!

- Амаа хамхи! Би тушаалыг биелүүлсэн, харин Горбаг тэр хөө хуяганд шунасан юм.

- Чи ч гэсэн дээ, би эндээ эзэн гээд л сагсалзаа биз дээ! Тэр чамд гол тагнуулыг бид хараагүй гэж өчнөөн удаа хэлэхэд чи чихээ бөглөсөн. Одоо ч гэсэн дүлий хэвээрээ байна, Горбагийн зөв гэж чамд хэлээд байна шүү дээ. Тэр тагнуул бидний хажууд байна, тэр бол эльф ч биш, тарк /орхууд гондорчуудыг тэгж нэрлэдэг/ ч биш, тэр наашаа ирж байна гэж чамд хэлээ биз дээ. Хонхны дуу сонссон уу? Тэр харуулуудын хажуугаар ороод ирсэн. Тэр энд байгаа цагт би доошоо буухгүй.

- Аа тийм үү? Тийшээ ч явахгүй, ийшээ ч ирэхгүй юм биз дээ? Тэрнийг хүрээд ирэхээр намайг хаяад зугтаах юм биз дээ? Тэгэхгүй шүү. Эхлээд би гэдсийг чинь баастай нь гаргаадхая!

Цамхгийн хаалгаар намхан орх гүйн гарч ирэхэд араас нь хүдэр том Шаграт байдгаараа бөхийж, бараг дөрвөн хөллөн харайж ирэв. Цусанд будагдсан нэг гар нь сулдаа унжиж, нөгөө гартаа том хар боодолтой юм барьжээ. Сэм шатны доор нуугдан зогсоод, түүний хумсанд уруулсан, цусан толбонууд хатсан хилэнт нүүр, арзайсан соёо, урсч байгаа шүлсийг нь бүдэгхэн улаан гэрэлд тод харав. Шаграт Снагаг хөөж, цаадах нь бултан зайлсаар цамхаг руу

байдгаараа хашгиран буцаж оров. Шаграт шатны хашлага түшин, унжиж байгаа зүүн гарынхаа сарвууг баруунаараа базан, амьсгаадсаар зогсч байлаа. Тэр боодолтой юмаа шалан дээр тавиад түүн рүү нулимснаа урт улаан хутгаа сугалав. Тэгээд шатны хашлага тэгнэн доод давхар руу харж байгаад байдгаараа бархирсан боловч хариу дуулдсангүй.

Гэнэт Сэм үхдлүүдийн нэг нь амилан хөдөлж, Шаграт руу мөлхөж очоод, нуруун дээрх боодолтой юмнаас нь татан босч ирэв. Тэрний гарт хавтгай өргөн үзүүртэй жадны хугархай байсан бөгөөд түүгээрээ Шагратыг сүлбэхээр завдсанаа сүүлчийн хоромд өвдсөндөө ч юм уу, орь дуу тавин хашгирахад Шаграт могой шиг мурьсхийн эргэж, тэрний хоолойд хутгаа зоож орхив.

- Сайн байна, Горбаг! Чи үхэж далд ороогүй байсан юм уу? За одоо үхнэ биз дээ! – гэж тэр архирав.

Тэр хөсөр унасан хүүрэн дээр галзуу мэт дэвсэлж, өшигчиж, хутгаараа сийчиж байснаа толгойгоо гэдийлгэн байдаг хоолойгоороо бархирав. Тэгээд хутганыхаа ирийг долоож, шүдэндээ зуугаад, боодолтой юм аа авч, шатны хаалга руу сажлав. Бодох цаг байсангүй. Сэм өөр хаалга руу ухасхийн орж амжих байсан ч харагдаж магадгүй, тэр амьтантай нуугдаж тоглох тун найдваргүй байсан тул Шагратын өөдөөс хашгиран дайрав. Түүнд бөгж байсан, мордорын ямар ч боол бөгжний аймшигт хүчийг мэдэрдэг, дээрээс нь Терн илд эльфийн нутгийн одод шиг гялалзаж байсан бөгөөд орхуудад түүнээс аймшигтай юм байхгүй билээ. Шаграт шууд л шатаар уруудан зугтаав.

Сэм түүний хойноос хараал тавин ухасхийснээ зогсов. Тэр түргэн зуурт Фродогийн тухай бодтол өөр нэг орх манааны цамхагт ороод ирэв. Бас л нүд ирмэх зуурт шийдвэр гаргах хэрэгтэй болов. Шаграт зугтсан юм чинь одоохон нэмэлт хүч аваад ирнэ. Түүний араас хөөвөл нөгөө орх нь яаж ч мэднэ... Шагратыг гүйцлээ ч гэсэн хэн нь дийлэхийг хэлэхэд хэцүү. Сэм буцаж дээшээ гүйв.

Тэр хооронд Шаграт шатаар гүйж буугаад хашаанаас үнэтэй ачаагаа тэврэн гарч гүйлээ. Тэр яагаад ингэж зугтаж байгааг Сэм мэдсэн бол өөр шийдвэр гаргах байв. Гэвч тэр зөвхөн Фродог хаанаас олохоо л бодож байлаа. Тэгээд цамхгийн хаалганд хүрч, дотогш харав. Тэнд харанхуй байсан боловч нүд нь дорхноо дасч, баруун талд нь бүдэгхэн гэрэл гарч байгааг харав.

Сэм болгоомжтой өгсч эхлэв. Хаалганы зүүн талд бамбар байгаа нь Фродо тэр хоёр ичээнээс гарч явахдаа харсан гэрэл мөн бололтой. Сэм хаалганы хажуугаар шурдхийн өнгөрч, гуравдугаар давхар руу яарав. Хаалга нээлттэй, харанхуй хонгилд бамбарын гэрэл бүдэгхэн тусч байв. Шат дуусч, Сэм хонгил руу орлоо. Хоёр талаар нь намхан хаалганууд түгжээтэй харагдана. Ямар ч чимээ сонсогдсонгүй.

Тэр хоёрдугаар давхарын хаалгыг татгал түгжээтэй байв. Тэгэхээр нь дахин дээш гүйлээ. Хөлс нь урсч, үнэт хором бүр үр дүнгүй өнгөрч байлаа. Тэр Шаграт, Снаг болон бусад орхуудыг мартаад, зөвхөн эзнийхээ царайг харж, гараас нь барихыг л хүсч байв. Эцэст нь туйлдаж гүйцсэн амьтан гуравдугаар давхарын шатан дээр суугаад гараа дэрлэн амсхийв. Ер бусын нам гүм. Бамбар асч дуусаад тас харанхуй нөмөрлөө. Гэнэт тэр өөрөө ч мэдэлгүй

дуулж эхлэв. Зүрх сэтгэл нь тэгж шийдсэн бололтой.

Түүний сулхан, чичирсэн хоолой харанхуй хүйтэн цамхаг дотор дөнгөж дуулдах төдий, ямар ч орх тэр дууг сонслоо гэхэд аймшигт эльфийн баатар дуулж байна гэж бодохооргүй байлаа. Тэрбээр ноён Бильбогийн зохиосон Хоббитанийн хүүхдийн дуу дуулж байлаа. Гэнэт түүнд их хүч нэмэгдэж, хоолой нь чангаран дууны үгийг өөрөө шууд зохиож эхлэв:

Тэнд нарны гэрэл цацарч

Хаврын цэцэрлэгийг гийгүүлэн,

Тал хөндий цэцэглэж,

Түмэн шувууд дуулж байгаа.

Сувдан оддын гэгээ

Навчсын дээр унаж байгаа.

Харин энд хав харанхуй,

Хамар дор үхэл нуугдаастай,

Ханьсах амьтан ч алга.

Хэн нэгний сулхан дуу сонсогдох шиг болов. Үгүй юм шиг байна аа, чагнаад ч дуулдах чимээ алга. Гэтэл хөлийн чимээ гарч, дээд талын хонгилд хаалга аяархан нээгдэн, түгжээ хяхтнах сонсогдов. Сэм амьсгаа даран атирлаа. Хаалга тасхийн хаагдаж, нэг орхын ууртай, гуншаа дуу гарав:

- За муу гөлөг минь, дахиад гоншгонох юм бол би чамайг нэг мөсөн дуугүй болгоод өгнө шүү! Ойлгов уу чи?

Ямар ч хариу байсангүй.

- Тэгж л таарна. Ямар ч гэсэн юу болоод гонгиноод байгааг чинь хараадхая – гэж Снага бувгнав. Дахиад түгжээ хяхтнаж, хаалганы завсраар туссан зурвас гэрэлд нэг орх шат бариад зогсч байгааг Сэм харлаа. Сэмийн толгойд нэг бодол гялсхийв. Снага шат тавин тааз өөд гараад түгжээ түчигнүүлэв. Дахиад дотор арзасхийм зэвүүн гуншаа дуугаар зандрах нь сонсогдов:

- Бүрэн бүтэн байгаадаа баярлаад чимээгүй хэвтэж бай! Удахгүй чи байхгүй болно, тэсч ядаад байна уу? Онгорхойгоо хамхи! Май, үүнийг ав!

Ташуур тасхийгээд явчихлаа. Сэм уураа барьж чадсангүй, чив чимээгүй гуравхан харайгаад шатан дээр гарав. Том дугариг тасалгааны дунд онгорхой хавхаг шиг юм байна. Улаан дэнлүү гинжээр дүүжилжээ. Баруун талдаа нарийхан цонхтой байв. Тэр цонхны дор хэн нэгэн

хэвтэж байх бөгөөд орх дэргэд нь бөхийн зогсоно. Тэр ташуураа дахин өргөсөн боловч ороолгож амжсангүй. Сэм түүн рүү хашгиран дайрахад орх эргэж харлаа. Терн илд гялсхийж баруун гарыг тас цавчив. Айсан өвдсөндөө муухай хашгиран тэр орх Сэм руу дайрав. Илднээс бултаж, Сэмийг түлхэж унагаад өөрөө ч уналаа. Сэм гялсхийн босч, орх шат мөргөж ойчихдоо онгорхой хавхаг руу толгойгоороо унасныг ойлгов. Сэм тэрнийг ор тас мартаад, шалан дээр атиран хэвтэж байгаа хүн рүү ухасхийв. Тэр бол Фродо байлаа.

Тэр нүцгэн, ухаангүй бололтой, гараараа толгойгоо халхлан хэвтэж байв.

- Фродо! Ноён Фродо, хайрт эзэн минь! Би Сэм байна! – гэж тэр нулимсандаа хахаж цацан хашгирав.

Тэгээд толгойг нь цээжиндээ наатал Фродо нүдээ нээлээ.

- Би дахиад л унтчихаа юу? Тийм зүүд бас байдаг аа.

- Үгүй ээ, эзэн минь, зүүд огтхон ч биш, бодит байдал. Би таныг оллоо.

- Хачин юм даа – гээд Фродо түүний мөрнөөс барьж:

- Дөнгөж сая энд ташуур барьсан орх зогсч байсан, тэгээд Сэм болоод хувирчих юм! Тэгэхлээр би хэн нэгэн дуулахыг сонсоод даган аялж байхдаа унтаагүй байсан хэрэг үү? Чи дуулсан уу?

- Өөр хэн байхав дээ эзэн минь. Би бүр цөхрөнгөө барчихаад байсан юм. Эрээд л байдаг, эрээд л байдаг, та олддоггүй.

- Ингээд би олдлоо. Сэм, миний эрхэм Сэм минь, - гээд Фродо дахин нүдээ аньж, хар дарж зүүдэлсэн хүүхэд ээжийнхээ дууг сонссон юм шиг Сэмийн гар дээр дэрлэн унтаад өгөв. Ингээд л суугаад баймаар, баярлаад баймаар байсан ч баярлах болоогүй гэдгийг Сэм ойлгож байв. Эзнийгээ олох нь ч оллоо. Одоо түүнийг аврах хэрэгтэй. Тэгээд Фродогийн духан дээр үнсэв.

- Сэрээрэй, сэрээрэй, ноён Фродо! – хэмээн тэр зуны өглөө Уутан хясаанд цонхны хөшгөө нээж байгаа юм шиг хөгжилтэй байхыг хичээн эзнээ дуудав.

Фродо нэгэнтээ санаа алдаад өндийж суулаа.

- Бид хоёр хаана байгаа юм бэ? Яаж яваад энд ирчихэв?

- Бүгдийг нь ярьж өгөмз, одоо эндээс аль болохоор холдъё. Товчхон хэлэхэд бид хоёр Шелобын ичээнээс гарч ирэхдээ харсан тэр цамхгийн орой дээр байна. Дараа нь таныг орхууд барьж авсан. Харин хэзээ болсныг санахгүй байна. Өдөр, шөнийн ялгаа байхгүй шүү дээ. Гэхдээ нэг хоногоос хэтрээгүй байх.

- Дөнгөж үү? Надад бүтэн долоо хоног өнгөрөх шиг л санагдсан. За за, дараа яриарай. Намайг цохиж унагасан, тийм үү? Би харанхуй ангал руу унах шиг санагдсан, дараа нь зөндөө

аймшигийг нүдээрээ харсан. Эргэн тойрон орхууд, тэд миний ам руу нэг муухай шингэн цутгаад байсан, тэгээд ухаан сэргэж, толгой өвдөөд, хөл хөдлөхгүй байсан. Намайг нүцгэлээд, хамаг юмыг минь хурааж аваад, хоёр аварга араатан намайг байцааж эхэлсэн. Эцэс төгсгөл байдаггүй, галзуурах байх гэж бодож байсан. Тэдний хумс, гал шиг нүдийг зуун жил өнгөрсөн ч мартахгүй!

- Бүү дурс, тэгвэл мартаж магадгүй эзэн минь. Гол нь эндээс хурдан холдох хэрэгтэй байна. Хэрэгтэй хэн нэгэнтэй учирч ч магадгүй. Та явж чадах нь уу?

- Чадна аа. Би шархдаагүй шүү дээ, Сэм. Гэхдээ хөдлөхөд хэцүү л байна, хүзүү өвдөөд байна.

Тэр босч, өрөөн дотуур явж үзээд:

- Зүгээр болчих шиг боллоо! Энд ганцаараа хэвтэж байхдаа хөдлөхөөс ч айж байсан юм. Дараа нь бөөн орилолдоон болж, орхууд алалцаад эхэлсэн. Намайг, бас олзоо булаалдах шиг болсон. Аймаар юм болсоон! Чимээгүй болсон хойно бүр ч аймаар байсан.

- Тийм ээ, тэд нар ширүүхэн зодолдсон байна лээ. Энд хоёр зуугаад юм байна. Ганц Сэм Скромбид арай л олдоно. Харин та бид хоёрт аз тохиолдоо. Дуу зохиох юм бол их л урт дуу гарна даа. Дараа л больё. Одоо хоёулаа яах вэ? Энд харанхуй ч гэсэн нүцгэн явж хэрэггүй байх.

- Тэд нар хамаг хувцсыг минь авчихсан. Бүгдийг нь! Ойлгож байна уу? Бүх юм өнгөрлөө, Сэм. Бид хоёр эндээс гарлаа ч гэсэн аврал байхгүй. Эльфүүд л аварч чадах байсан, гэвч тэд дэндүү хол байна...

- Үгүй ээ эзэн минь, бүх юм өнгөрөөгүй байна. Би энийг таны хүзүүнээс тайлаад авчихсан юм, өгөөмөр сэтгэл гаргаж наймайг уучлаарай. Бөгж миний хүзүүнд байгаа! Одоо таны хүзүүнд зүүчихье – гээд Сэм гараа өвөртөө хийсэн боловч бөгжийг эзэндээ өгмөөргүй байлаа. Эзэн минь яаж ийм хүнд ачаа зүүж явах вэ!

- Чамд байгаа юм уу? Гайхамшигтай! Нааш нь өгөөтөх одоохон! Тэр чинийх биш!

- Тэгэлгүй яах билээ эзэн минь. Май! - гээд тэр бөгжийг дуртай дургүй тайлж:

- Гэхдээ бид хоёр Мордорт байгаа шүү дээ. Энэ цамхгаас гараад Галт уул болон өөр бусад юмыг харна. Бөгж хачин их хүндэрсэн, тэрнийг энд авч байх аюултай. Ээлжээр авч явах уу?

- Үгүй үгүй! – гэж Фродо хашгираад бөгжийг шүүрэн авч:

- Тэгж бодохын ч хэрэггүй, муу хар хулгайч!

Сэм өмнө нь сөхрөн суугаад үхтлээ гомдсондоо мэгшин уйлж байгааг тэр гэнэт мэдэв.

- Сэм минь дээ! Би юу гээд хэлчихэв! Би яачих нь энэ вэ! Намайг өршөө! Би чамд баярлах ёстой байтал... Хэзээ ч энэ хараалыг олохгүй байсан ч болоосой. Энэ бөгж аймшигийн их хүчтэй. Ойлгож үз, Сэм, би нэгэнт энэ ачааг үүрснээс хойш одоо яая гэхэв. Энэ бол миний

тавилан, чи хүртэл үүнийг хуваалцаж чадахгүй.

- За тэр яахав эзэн минь, - гээд Сэм ханцуйгаараа нулимсаа арчиж:

- Бүгд ойлгомжтой. Би хуваалцаж чадахгүй ч гэсэн тусалж чадна. Юуны өмнө эндээс хурдан гаръя. Та хувцас өмсч, жаахан тэнхрэх хэрэгтэй. Нэгэнт л Мордорт байгаагаас хойш би таныг мордор маягаар хувцаслана. Хоёулаа орхын хувцас өмсөөд явна. Ер нь тэгсэн нь аминд өлзийтэй байх. Одоохондоо үүнийг өмс!

Сэм саарал цуваа тайлж, Фродод өмсгөв. Дараа нь үүргэвчээ газар тавиад Терн илдээ сугалж харахад ир нь үл мэдэгхэн гэрэлтэж байв.

- Хараач эзэнтээн! Тэд бүх юмыг чинь мулзалчихаагүй байгаа биз дээ. Тернийг би танаас зээлсэн юм, харин хатан хааны аягыг та өөрөө надад өгсөн, санаж байгаа биз дээ. Маш их хэрэг болсон шүү. Одоо дахиад хэсэгхэн зуур зээлчих, би олзонд яваад ирье. Тэр хооронд та хөлийнхөө чилээг гаргаж бай. Одоохон ирнэ.

- Болгоомжтой л яваарай, Сэм! Түргэн ирээрэй!

- Тэгэлгүй яахав – гээд Сэм хавхгаар доош бууснаа нэг минутын дараа түүгээр толгойгоо цухуйлгаад урт хутга шидэж:

- Юу ч гэсэн энийг авч бай. Таныг ташуураар ороолгосон этгээд үхчихсэн байна. Яарч байгаад хүзүүгээ хугалчихаж. Та намайг дуудахаар шат буулгаарай. Би “Элберет” гэж хэлнэ. Эльф үгийг энд хэн ч мэдэхгүй.

Фродо саяхан болж өнгөрсөн айдсыг санан, өчүүхэн төдий чимээнд ч давхийн цочиж суулаа. Тэгээд босч, хар муу бодлыг хөөхийн тулд эльфийн цуваа хөдрөөд, харанхуй өрөөний булан бүрийг нэгжин нааш цааш холхив. Удаан хүлээсэнгүй, доороос Сэм: “Элберет, Элберет” хэмээн аяархан дуудав. Фродо хөнгөн шатыг хавхгаар доош буулгахад Сэм толгой дээрээ том боодолтой юм тавиад уухилан гарч ирэв.

- Түргэлж үзье, эзэн минь! Энэ хувцаснуудыг углачих. Яаж ийгээд болно оо, цаг алга. Орхууд бүгдээрээ үхсэн байна. Юу ч үзэгдэж харагдахгүй мөртөө далдаас хараад байгаа юм шиг санагдаад байна.

Тэр боодолтой юмаа тайлахад Фродо хараад ой гутах шиг санагдсан ч шалдан явалтай биш, ямааны арьсаар хийсэн бололтой урт өмд, нэл тос, хир даг болсон цамц углаад, уртдаж элбэгдсэн хүнд хар хуяг өмсөв. Тэгээд богинохон, өргөн хутга зүүлттэй бүс бүсэллээ. Сэм таван дуулга авчирснаас Фродод төмөр бүрээс, ширэн гадартай, улаан нүд зурсан хар малгай таарав.

- Моргулийн хуяг дуулга, Горбагийн цэргүүдээс тайлж авлаа. Гэхдээ энд ийм сүртэй зодоон болсны хойно ийм хувцастай ил явж болохгүй. За эзэн минь, одоо бэлэн боллоо, замдаа нэг бамбай аваад барьчихна биз.

- Чи яах вэ, Сэм? Бас ийм юм өмсөх үү?

- Тийм ээ, гэхдээ хувцсаа энд орхиж болохгүй, дээр нь давхарлаж углахаас биш.

Тэр эльфийн цуваа нямбайлан эвхэж, жижигхэн боодол болгов. Тэгээд үүргэвчдээ хийж, хар цув хөдөрлөө.

- За ингээд хоёулаа орх шиг болчихлоо. Явж үзье!

- Гэхдээ гүйхгүй шүү, Сэм. Чи хоол ундны талаар юу гэж бодож байна? Эсвэл ууж идэхээ больчихсон уу?

- Нээрэн таг мартчихаж! Таныг сануулахаар өлсч цангаж байгаага мэдлээ! Үүргэвчинд аяны талх жаахан үлдсэн, Фарамирын өгсөн хүнс ч байгаа. Бага шиг идээд байвал хоёр долоо хоногт хүрнэ. Дашмаганд жаахан ус байна. Хоёр хүнд ч багадана даа. Энэ орхууд идэж уудаг юм болов уу?

- Иддэг ч, уудаг ч, Сэм. Өмхий ус ууж, илжирсэн мах иддэг. Надад ч гэсэн хоол, унд өгч байсан шүү. Энд хаа нэгтээ идэж уух юм байх л ёстой.

- Даан ч эрэх зав алга даа.

- За яахав, бид хоёрын байдал харин ч дажгүй байна. Чамайг байхгүй хойгуур би өөрийнхөө үүргэвчийг хогон дотроос олж авсан. Тэд онгичиж, цөлмөсөн боловч аяны талханд Хорлумаас ч дургүй бололтой. Харин Фарамирын хүнсийг цөлмөөд, дашмагийг минь хэдэн хэсэг болгочихсон байна.

- Тэгвэл одоохондоо өлсч үхэхгүй л юм байна. Ус багатай жаахан тиймхэн байна даа. За хөдөлье эзэн минь!

- Үгүй ээ, Сэм, идэхээс нааш хөдлөхгүй шүү. Май, энэ талхыг ид, тэгээд уснаасаа балгачих!

Тэр хоёр доош бууж, Сэм шатыг дор орхив. Тэгээд арай хөнгөн хоёр бамбай аваад гол шат руу буув. Тэр хоёрын сая байсан өрөө энэ хонгилыг бодвол төрөлх гэр шиг нь санагдаж байлаа. Кирит-Унголын цамхагт нэг ч амьд амьтан байхгүй юм шиг ер бусын анир чимээгүй байв. Орхуудын хүүрэн дундуур явсаар хаалганд хүрлээ. Фродо тамир алдран чулуун дээр сандайлж суув.

- Цаашаа явж чадахгүй нь ээ, Сэм. Ингээд л үхэх гэж байгаа юм шиг санагдаж байна. Гэхдээ эндээс гарахгүй бол би Фродо биш болог. Яагаад ингэж их ядарч байгаагаа ойлгохгүй байна.

Тэр өврөөсөө Галадриэлийн аягыг гаргаж ирэхэд, харанхуй хашааг цахилгаан мэт гэрэлтүүлэв.

- Гилтониэль, о Элберет! – хэмээн Сэм дуудахад гэнэт Хоббитани орон, эльфүүдийн дуу санагдав.

- Аийя эленион анкалима! [Оддын хатан хаан минь!] – хэмээн Фродо дуу алдлаа..

Тэгмэгц ядаргаа нь ор мөргүй алга болж, Фродо, Сэм хоёр хаалгаар гүйн гарлаа. Тар няр хийсэн чимээ гарч, нуман хаалганы тотго чулуу газарт унан бут үсрэв. Хоббитууд тэр чулуунд хариугүй даруулчих дөхөв. Хонх дүн данхийн, амьгүй харуулууд зэрлэгээр хашгиралдав. Харанхуй тэнгэрт зэвүүн муухай орилох дуу цууриалж, далавчит сүг сүүдрүүд үүлсийг яран элээ мэт шунгинан дайрав.

Бүлэг 12

Бүрэнхий хязгаарт

Сэм гэрэлт аягаа дөнгөж өвөртөлж амжив.

- Зугатъя, эзэн минь! –Биш ээ, тийш ээ биш! Тэр ханын дор ангал байгаа. Миний хойноос гүй!

Тэр хоёр шууд л замаар гүйв. Тавиад алхам гүйтэл аврагч хясаа тэднийг нууж, нуруугаараа хясаа налан амьсгаа дарлаа. Нурсан нуман хаалганы зүгээс далавчит сүгнүүдийн зүрх зүсэм орилоон хадаж, хад асга доргиж байлаа. Тэр аймшиг мань хоёрыг гүйцсэн тул хясаанаас цааш бас л ил гүйх хэрэгтэй болов. Хэрмэн дээгүүр хар сүүдэр нөмрөхийг хальт хараад тэр хоёр Моргулийн зам руу эгц буусан жалганд нуугдав. Төдөлгүй уулзварт хүрэхэд эргэн тойронд хэн ч байхгүй байсан боловч далавчит сүгнүүдийн улангассан дуунаар тал талаас гүйлдэн ирэх нь гарцаагүй байв.

- Бид хоёр ч баларлаа даа, Сэм. Хоёулаа орх байсан бол цамхаг руу гүйхсэн, биш болохоор гүйх газар алга даа. Дор нь л базаад авна. Замаар бүр ч болохгүй.

- Болохгүй нь ч болохгүй л дээ. Тэглээ гээд хаашаа алга болох вэ дээ, бид хоёр ямар нисдэг биш. Хажуу талаас Эфель-Дуатын зүүн хавцлууд шахна. Зам уулзвар өнгөрөнгүүт дахиад л ангал дээгүүрх дүүжин гүүрээр гарч, Моргвейн хясаанууд руу хөтлөв. Фродо, Сэм гүүр рүү хөлийн хурдаар гүйж, Кирит-Унголын цамхаг хадан хайрсаа гялалзуулсаар тэртээ ард хоцров. Гэнэт хонх дүнгэнэснээ тасралтгүй янгинав. Бүрээнүүд цангинан цууриалав. Гүүрний цаанаас хариу өгч байгаа бололтой хашгиралдлаа. Галт уулын гэрэл тэр хонхор руу орохгүй байсан учир тэнд юу ч харагдсангүй, зөвхөн тахтай гутлын түжигнээн, туурайн чимээ улам ойртсоор байлаа.

- Түргэлээрэй, Сэм! Гүүрнээс үсэр! - гэж Фродо хашгирав. Тэр хоёр гүүрний хашлага давав. Аз болоход ангал өнгөрсөн боловч харанхуйд таамгаар үсрэх хэрэгтэй байлаа.

- Ээ, ийм юм анх удаа л үзэж байна. Юу ч гэсэн баяртай гэе дээ, эзэн минь! – гээд Сэм үсэрлээ. Фродо араас нь үсрэв. Тэдний толгой дээгүүр, гүүрээр морьт цэргүүд болон явган орхууд пижигнэлдэн өнгөрч байлаа. Сэм тачигнатал инээхээ шахав. Тэр хоёр ёроолгүй ангал руу унасангүй, арзгар хадан хясаан дээр ч унасангүй, харин арван хоёр орчим тохой өндрөөс өтгөн шигүү бутан дотор унажээ. Сэм чимээгүй хэвтээд, бутанд маажуулсан гараа долоолоо.

Чимээ намжингуут тэр зориглон шивнэв:

- Эзэн минь, би Мордорт ямар нэг ургамал ургадаг гэж огт санасангүй, гэтэл ургадаг юм байна. Ургах ургахдаа бүр бараг хоёр хуруу урт өргөстэй байдаг байна шүү! Яаж намайг нэвт сүлбэчихээгүй юм бол доо. Хуягаа өмсдөггүй мөн ч тэнэг амьтан юм даа би.

- Орхуудын хуяг ямар ч хэрэггүй юм байна, цувыг маань өргөс урчихаж - гэж Фродо хариулав.

Буган шугуйгаас арайхийн гарч ирцгээв. Төмөр утас мэт хатуу мөчиртэй бутнууд хоорондоо барьцалдан нийлсэн учир цувнууд нь сэг болтлоо урагджээ.

- Доошоо бууя, Сэм. Хонхрын бүр ёроолд хүрээд хойт зүг рүү эргэе - гэж Фродо шивнэв.

Мордорын хилээс гадуур өглөө болж, Дундад газрын дорно хязгаараас нар хөшгөн мананг нэвглэн гарч ирсэн боловч Мордорт харанхуй улам өтгөрч байв. Түр унтарсан галт уулнаас утаа уугина. Түлэгдэн хүрээнтсэн хадан хясаанууд харлажээ. Хоббитуудыг Итилид байхаас үлээсэн бүлээн салхи намджээ. Мань хоёр маш удаанаар, унан тусан байж, өргөст бут, хад асган дундуур уруудсаар л байлаа. Эцэст нь явах тэнхэлгүй болж, хөлс нь урсан нэг том хадны ёроолд зэрэгцэн суув.

- Ганц аяг ус өгвөл би Шагратын саврыг ч атгахад бэлэн байна – гэж Сэм хэлэв.

- Усны тухайд бол таг дуугүй байсан нь дээр! Битгий ухаан самууруулаад бай - гэж Фродо хэлэв

Тэр хөлөө жийн хэвтээд удаан дуугүй байлаа. Дотор нь муухай болж байв. Нэг харсан чинь Сэм бөх гэгч унтаж байлаа.

- Сэм, сэрээрэй! Явах хэрэгтэй! Амарч авлаа, алхаад байя.

Сэм ухасхийн босов.

- Эцэг минь! Өөрөө ч мэдэлгүй унтчихдаг байна шүү. Эзэн минь, унтаагүй удсан болохоор аяндаа л унтчихлаа.

Фродо түрүүлж, хуурай голдрилыг дүүргэсэн чулуун дундуур хойт зүгийг чиглэн алхав. Гэвч хэсэг яваад зогсов.

- Үгүй ээ, Сэм, яагаад ч болохгүй байна, би орхын хуягны тухай ярьж байна. Өөр тохиолдолд өмсч болох юм. Харин одоо бол үгүй. Миний мифриль хуяг хүртэл надад хүнд юм шиг санагддаг байсан, гэтэл энэ бол арай хэтэрхий хүнд юм байна. Тэгээд ч ер нь ямар хэрэгтэй юм бэ? Бид ямар тулалдах гэж байгаа биш.

- Тулалдахгүйгээр дайсны хүрээнээс гарч чадна гэж үү? Нуруу руу хутга дүрэх ч юм уу, тэнэсэн сум оночих ч юм уу алийг тэр гэхэв. Бас Хорлум хаа нэгтээ ойрхон шиншилж яваа. Таныг ганц арьсан цамц хамгаална гэж би бодохгүй л байна шүү!

- Сэм, анд минь, би их ядарсан, хөл дээрээ ч тогтож чадахгүй болох нь, би юунд ч найдахгүй байна. Гэлээ ч гэсэн тэр Галт уул руу мөлхөөд ч хамаагүй явах хэрэгтэй. Энэ бөгж намайг тамлаж ханалаа. Энэ илүү ачаа намайг дарамталж байна. Гэхдээ чи үүнийг надад олж өгөх гэж овоолттой хүүр ухах чамд ямар байсныг би ойлгож байна аа...

- Тэр яах вэ эзэн минь, ажил маань л хэцүү байна! Би таныг үүрээд хаана ч хамаагүй хүргэнэ. Тэр бөгж чөтгөр рүүгээ тонилог!

Фродо цуваа тайлж, хуягаа тайлан шидэж орхив.

- Дулаан юм өмсөх юмсан, хүйтрээд байна уу, би халуураад байна уу?

- Миний цувьг өмс, эзэн минь – гээд Сэм үүргэвчээ задлан, боодолтой юм гаргаж:

- Дажгүй шүү. Орхын энэ навтсыг өмсөөд бүсээ бүсэлж, зүүлтээ зүү. Та ингэлээ гээд орх болчихгүй, харин дулаацна. Хатан хааны гар хүрсэн болохоор энэ таныг хамгаална.

Фродо зүүлтэн товчийг товчлов.

- Бие хөнгөрөөд явчихлаа! Хөл ч чангарлаа. Ганцхан толгой л дөшинд хавчуулсан юм шиг өвдөж байна. Сэм, би цамхагт хэвтэж байхдаа Брендидуим, ойн булан, Норгордын голын ойролцоох тээрмийг санаж байсан. Харин одоо юу ч санахгүй байна.

- Эзэн минь, одоо би биш, та өөрөө усны тухай битүүхэн яриад эхэллээ! Хатан хаан бид хоёрыг харж, сонсч чаддагсан бол би түүнд: “Эрхэм дээдэс ээ, бид хоёрт зөвхөн өдрийн гэрэл, цэвэр ус хоёр л хэрэгтэй байна, энэ чулуунууд огт хэрэггүй” гэж хэлэх байлаа. Даанч Лориэн хол байна даа.

Сэм санаа алдаж, Изгарын уулсын зүг гараараа савав. Зуугаад алхам яваад Фродо дахин зогслоо.

- Хар морьт бидний дээгүүр эргэлдэж байна. Би энийг мэдэрч байна. Жаахан хүлээе.

Тэр хоёр асар том хадны хөмсөг доогуур орж, өөд өөдөөсөө харан чимээгүй суув. Дараа нь Фродо санаа амарсан байртай урт амьсгаа аваад:

- Явчихлаа.

Тэр хоёр гадагш гарч ирээд мэл гайхан зогсов. Зүүн талд тэнгэрийн хаяа сааралтан, шовх оройт уулс үзэгдэв. Цаанаас нь гэгээ цацарч, харанхуй манан хойт зүг рүү ухран, тэнгэрт их тулаан болж байгаа юм шиг санагдав. Мордорын хар үүл бөөгнөрөн шингэрч байлаа. Тэгээд өглөөний цайвар гэгээ тусав.

- Хараач, эзэн минь! Салхи өөрчлөгдлөө. Дайсны бүх юм сайхан биш байгаа бололтой. Тэр яаж байгаа бол, харах юмсан – гэж Сэм хэлэв.

Энэ бол гуравдугаар сарын арван тавны өглөө байсан бөгөөд нар Андуины дээгүүр гийж, баруун өмнө талаас салхилж байв. Теоден яг энэ үед Пеленнорын талд амьсгаа хурааж байлаа. Эфель-Дуатын дээгүүр гэгээ татаж, хоббитууд гэнэт цэлмэг тэнгэрт нэг толбо гарч ирэхийг харсан бөгөөд хурдан томрон наашилж толгой дээгүүр нь хар сүүдэр татуулан өнгөрөв. Хар сүг сүүдэр удаанаар орь дуу тавин бархирч байсан боловч огт айдас төрүүлсэнгүй, оргүй алга болж байгаагаа зарлах мэт байв. Бөгжтөнгүүдийн толгойлогч ийнхүү энэ ертөнцөөс тониллоо.

- Би юу гэж хэллээ? Хар үйлтэн хаа нэгтээ сөнөж байна. Шаграт “Дайн сайхан болж байна”

гэж хэлэхэд Горбаг “хм” гэж байсан. Дэмий нэг тэгээгүй юм шиг байна. Тийм ч муу биш байна шүү, эзэн минь. Найдах юм байна даа.

- Үгүй дээ, Сэм минь, чи бид хоёрт найдах юм байхгүй. Уулсын цаана, уудам хөндийн цаана л ийм юм болж байна. Харин бид хоёр баруун тийшээ биш, зүүн зүг рүү явж байгаа. Би их ядарч байна. Сэм, бөгж улам л хүндрээд байна. Нүдний өмнө галтай дугуй эргээд байгаа юм шиг санагдаж байна.

Сэм дахин уруу царайлав. Тэр эзэн рүүгээ түгшин хараад гараас нь барилаа.

- Явья, эзээн! Ямар ч гэсэн гэгээ орлоо. Явахад хөнгөн боллоо. Хэсэг яваад жаахан хэвтэж амарна. Эльфийн талхнаасаа идчихвэл тэнхээ орно. Тэр хоёр аяны талхнаасаа нэгийг хувааж зажлаад замдаа орлоо.

Дөт замаар явах аюултай байсан боловч Фродо Моргвейн хавцлын хад асган дундуур явж дийлэхгүй гэдгээ мэдэж байлаа. Тэгээд ч араас хөөвөл тэр хоёрыг энд биш, эхлээд зүүн зам болон баруун даваан дээр хайх болно. Энэ хооронд бид хоёр цамхгаас холдож, хонхроос зүйн тийш гарахыг оролдоно. Тэнд гараад авбал... тэгээд л бүх зүйл дуусна гэж тэр бодож байлаа. Тэр хоёр хуурай голдрил гаталж, орхуудын замаар оров. Дээрээс нь хясааны хөмсөг өнгийж байсан болохоор тэр зүгээс айх юм бараг байсангүй, харин зам хэсэг яваад эргэж байсан тул мань хоёр эргэлт бүр дээр илдээ сугалж байлаа.

Харанхуй бүрэнхий дундуур бүдчин явсаар гэнэт чихэндээ ч итгэлгүй нам зогсов. Ус урсах чимээ тодоос тод сонсогдож байлаа. Зүүн талд, хар хясааны дундуур хага зүссэн юм шиг нарийхан сувгаар ус урсч байв. Тэр ус зам гатлаад нарийхан горхи болон нүцгэн хад чулуун дундуур бараа алдарчээ.

Сэм ус руу ухасхийв:

- Хэрэв хатан хаантай уулздаг л юм бол энэ тухай заавал ярина! Гэрэл өгөөч гэхэд өгсөн, ус гуйхад бас л өглөө! – гэснээ жаахан тээнэгэлзээд:

- Эзэн жаахан хүлээж бай, эхлээд би уугаад авья.

- Уу, уу, гэхдээ зэрэгцэж хэвтээд уухад ханалттай зай байна шүү дээ.

- Би тэр тухай яриагүй, зүгээр л ус уунгуугаа талийгаач болж магадгүй гэж болгоомжлоод л...

- Аа, тийм үү. Үгүй ээ, хоёулаа зэрэг ууна. Эхлээд маш бага амсаадахья. Ямар хүйтэн байх бол доо!

Ус хүйтэн биш сэрүүхэн, тосорхог, гашуувтар амттай байв. Гэртээ байсан бол тэр хоёр ингэж бодох байсан байх, харин энд ус олдсон нь дээдийн заяа учир айх юмгүй ханатлаа залгилав. Сэм дашмагаа дүүргэж аваад, хэдэн бээр газар алхав. Фродогийн бие ч хөнгөрлөө. Жим өргөсч, баруун талд хана маягийн бүдүүлэг хийц харагдав. Орхуудын хуаран ойрхон байгаа бололтой.

- Зүүн тийшээ эргэе, Сэм. Тэнд хүрч чадах байх. Тэгээд нэг хонхор олж амарья.

Нурамхай хажуу руу гулсан буутал нэг биш хэд хэдэн горхи бүхий хонхор газар байв. Тачир ургамал амьдралын төлөө тэмцэж, нууцхан ургасан байлаа. Орхууд шиг улаан толботой хар, саарал ялаанууд шунгинан нисч, өлсгөлөн шумуул үүл мэт бүрхэн дайрлаа.

- Орхын хуяг тус болохгүй юм байна. Надад орхын арьс л хэрэгтэй байна – хэмээн Сэм хоёр гараараа шумуултай байлдах зуур хэлэв. Фродо бүр туйлдаж гүйцэв.

- Би амарлаа, Сэм, унтах гээд үзье - гээд Фродо эргэн тойрныг харахад араатан ч нуугдах газаргүй нүцгэн ханаас өөр юм алга. Тэгээд нэг том бутны ёроолд тухлав. Аяны талхаа хэмнэхээр шийдсэн тул Фарамирын хүнснээсээ хатаасан алим, солонин идлээ. Ус ханатлаа уусан боловч Мордорын хуурай агаар үргэлж ам хатааж байлаа. Сэм усны тухай бодоод бүр урам хугарав. Одоо Горгоротын хатсан тал руу орох ёстой байлаа.

- Та унт эзэн минь, дахиад л харанхуйлж эхэллээ. Үдэш болсон юм шиг байна.

Фродо Сэмийг ярьж дуусаагүй байхад унтаад өгөв. Сэм Фродогийн гараас бариад тас харанхуй болтол суув. Үүлний завсраар одод харагдаж байна. Оддын цэвэр, тунгалаг туяа түүний сэтгэлийг сэргээж, өөрийнхөө ч, эзнийхээ ч хувь заяанд санаа зовохоо гэнэт болилоо. Тэгээд Фродогийн хажуугаар хэвтэж, аливаа айдсыг таг мартаад, бөх гэгч нойрсов.

Хичнээн унтсаныг бүү мэд, өдөр болсон шинжтэй байв. Идэж, ууж аваад хавцлаар дээш авиран, нүцгэн хадан цохионуудад хүрэв. Сүүлчийн зуун алхам газрыг ангалын ирмэг дээгүүр мөлхөж туулаад, Мордорын доод хэрмийн захад хүрэв. Хясаанаас доош Горгоротын хоосон хөндий бүрэнхийд зах нь харагдахгүй үргэлжилж, өрнийн салхи нүсэр том үүлсийг хөөн сарниулж, уйтгарт хар талд бүдэг цайвар гэгээ тусчээ. Дөчөөд бээрийн цаана Галт уул хар утаанд хучигдсан хүчирхэг оргилоо сүндэрлүүлэн харагдана.

Фродо, Сэм хоёр айж, гайхсан нүдээр орчныг харж байв. Тэр хоёрын байгаа газраас Галт уул хүртэл үхмэл, шатаж үнс болсон цөл газар л харагдана. Хар эзэн тэр үй олон боолууд, тоо томшгүй цэргүүдээ юугаар тэжээдэг юм бол? Моргвейн бэлээр тоолж баршгүй олон шавар, майхан хуарангууд шавааралджээ. Яг тэдний байгаа хясаан дор нэг том хуаран байна. Тэр хуаран, Моргул руу явах замаар цэргүүд шоргоолж шиг язганалдана.

- Энэ ч надад нэг л таалагдахгүй байна даа. Бид хоёрын ажил ч өнгөрлөө дөө гэж хэлэх байна. Гэхдээ хаана хүн амьтан олон байна, тэнд ядаж худаг байх ёстой. Эд нар чинь орхууд биш, хүмүүс байна шүү дээ. За яахав, эд нар ус, хоолоор хахаж байлаа ч гэсэн бид хоёрт өгөх юм биш. Харин доош буух арга алга. Буулаа ч гэсэн энэ язганасан олон амьтны хаагуур нь гарах болж байна? – гэж Сэм хэлэв.

- Одоо яахав, оролдоод л үзнэ дээ. Би энэнээс өөр юм хүлээж байгаа гэж бодоогүй. Ууланд хүрч чадна гэсэн найдвар угаасаа бидэнд байсан гэж үү? Одоо ч гэсэн би найдахгүй байна, гэхдээ буцах зам байхгүй. Одоохондоо тэдний саварт базуулчихалгүй аль болохоор удах хэрэгтэй. Эхлээд хоёулаа хойт зүг рүү явж, тэнд юу болж байгааг харсан нь дээр байх.

- Тэнд юу болж байгааг одоо ч гэсэн би мэдэж байна. Хөндий нарийссан газарт орхууд болон хүмүүс өт шиг чихцэлдэн язганалдаж байгаа. Та өөрөө үзнэ биз дээ, эзэн минь.

- Амьд байвал үзнэ дээ.

Тэр хоёр буцаж хонхор руу ороод, асга чулуун дундуур гэлдрэв. Нэг бээр орчим яваад хясааны ирмэг дээр нуугдан эргэн тойрныг тандав. Хонхрын цаад талд орхуудын хуаран байна. Түрүүчийн харсан бүдүүлэг шавар хана, агуйн хар ам онгойн харагдах бөгөөд амьд амьтан харагдаагүй боловч хоёр хоббит хулгана шиг бутнаас бут руу тонгойн гүйсээр байлаа. Аз болоход хоёр талаар өтгөн бут ургасан байлаа. Хоёр гурван бээр ингэж явсны дараа орхуудын хуаран далд орж, дөнгөж амьсгаагаа дартал зэрлэг чанга дуугаар ярилцах сонсогдлоо. Мань хоёр нэгэн том бутны цаагуур гялсхийн оров. Ярилцах дуу ойртсоор хоёр орх гарч ирэв. Нэг нь уранхай, гандмал цувтай, эвэр нумтай бөгөөд тагнуул бололтой хамраа сарталзуулан үнэрлэж, ийш тийш олилзон харж явна. Нөгөө нь Шагратын цэргүүд шиг өндөр том биетэй, нүд зурсан хуяг дуулгатай, урт жад, нум сумтай ажээ. Мэдээж, орхууд болсон хойно хэрэлдэж явна. Хоббитуудын нуугдсан бутнаас хориод алхмын цаана ирээд тагнуул орх зогсов.

- Гүйцээ! Би буцлаа. Ямар ч ашиггүй чулуу үнэрлэсээр байгаад хамар өвдөж байна. Чамаас болж мөр алдсан. Уул руу явсан гэж би хэлээд байхад чи нам газар, нам газар л гээд байсан биз дээ.

- Юу гэнэ ээ, нусны нүх чинь битүүрчихээ юу? Хамраараа газар ухахаа болиод нүдээрээ харж яв!

- Чиний наад хоёр ёлтгор чинь юу харав? Хэнийг хайж байгаагаа мэдэхгүй байж. Муу хар муна!

- Бүү донгос! Яах ёстойг би мэдэж байна! Эхлээд гялалзсан хуяг дуулгатай эльфийг барь гэсэн, дараа нь гномыг барь гэсэн, одоо болохоор урукхай нар үймээн гаргаад, тарж зугтсан гэнэ. Олоод бариад ир, хэн ч байсан хамаагүй гэнэ ээ.

- Түй! Их ухаанаасаа болиод галзуурцгаачихаж л дээ. Тэдний тархийг ч засаад өгнө, далиманд нь арьсыг нь хуулаад өгнө гайгүй. Цамхгийг дайрч эзлээд чам шиг гурван зуу гаруй үхдлүүдийг сэглэж хаясан, олзны өт нь зугтаачихсан гээ биз дээ. Та нар ч таарсан зодоочид доо! Дайны үеэр ч гэсэн уралцаж л байдаг.

- Хэн тэгж хэлээ вэ?

- Юундаа орилоод байгаа юм бэ? Худлаа юм уу, тэгээд?

- Ийм юм ярьсны чинь төлөө муу эсэргүү чамайг би гамбир болгочихно шүү! Хамар доорхоо хамхи, ойлгов уу?

- За за, би амаа хамхия, надад юуны хамаа. Дотроо бодоод явж болно. Харин чи надад хэлээтэх. Тэр намгийн өмхий чинь юу юм бэ? Тас хар, урт сарвуутай?

- Би яаж мэдэх юм бэ? Бас л нэг үхэж далд орсон тагнуул биз! Тэр зугтаачихсан, гэтэл даруйхан барьж ир гэж тушаасан гэж байгаа.

- Хурдхан барьж аваад мөч мөчөөр нь жиргэвэл сайнсан. Тэр л мөр алдуулсан, бас хуяг аваад явчихсан.

- Хуяг байгаагүй бол ч тэр аль хэдийн хүүр болсон л доо. Би амьдаар нь барь гэснийг тэгэхэд мэдээгүй, тавин алхмаас нуруу руу нь сум зоосон чинь сум халт үсрээд, нөгөөдөх чинь улам хурдан гүйсэн шүү

- Худлаа ярих газраа очиж чалч! Алдчихаад. Харваж чадахгүй, гүйхдээ яст мэлхий шиг, тагнуулч бид та нарын өмнөөс гүйх юм даа. Чөтгөр рүүгээ тонил – гэгчихээд тагнуул орх гүйгээд явчихав.

- Буцаад, новш оо! Илтгэнэ шүү!

- Хэнд илтгэх юм бэ чи? Хайрт Шагратдаа юу? Тэрний захирдаг хөг нь өнгөрсөн.

- Чиний нэр, дугаар хоёрыг далавчит сүүдэрт илтгэнэ. Тэр ойрхон байгаа, цамхгийг одоо тэр захирч байгаа.

- Аа муу жингэрийн чацга, дутуу төрсөн ховч! Өөрөө гай болчихоод өөрийнхнөө зарах нь уу! Тэр өмхий орилоо руугаа очихгүй юу. Тэр өөрөө хүүр болчихоогүй бол шөрмөсийг чинь сугалаад өгөх байлгүй. Нэгийг нь аль хэдийнэ зүйл дуусгасан гээ биз дээ?

Өндөр орх түүн рүү жадаа барин дайртал тагнуул орх бултан зайлж, хадны цаагуур ороод өндрийн нүдэнд сум зоож орхив. Аварга орх нам унаж, намхан нь эргэж ч харалгүй гүйж одов. Хоббитууд хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй хэсэг суув. Эцэст нь Сэм:

- Цэвэрхэн ажиллаж байна. Бид хоёрыг бол ийм маягаар тун ч амархан зүйл дуусгах юм байна даа!

- Чимээгүй, Сэм. Хоёулхнаа биш байсан ч байж мэднэ. Чи бид хоёрт аз тохиолоо. Яг араас мөшгөж явсан байна шүү дээ.

Дахиад нэлээд удаан чимээгүй сууснаа Сэм шивнэв:

- Намгийн өмхийн тухай сонсов уу, эзээн? Манай Хорлум амьд мэнд яваа гэж би эс хэллүү, санаж байгаа биз дээ?

- Санаж байна. Тэгэхэд би чамайг яаж мэдэж байгаа юм бол гэж гайхаж байсан юм. За, яаж мэдсэнээ ярь! Харанхуй болтол эндээс гарсны хэрэггүй гэж би бодож байна. Харин аяархан л яриарай.

- Хичээж үзье, гэхдээ би тэр өмхийн тухай ярих гэхээр байдаг хоолойгоороо хашгирмаар л байна.

Мордорын үдэш аль хэдийн өнгөрч, од ч үгүй харанхуй шөнө болов. Тэр хоёр суусан чигээрээ, Сэм Хорлумын хар санаа, хорт могой Шелобын тухай, Хорлум орхуудын хойноос явсан тухай шивнэн ярив. Фродо юу ч хэлсэнгүй, зөвхөн Сэмийн гарыг чанга атгаад:

- За, сууж ханалаа. Одоо биднийг багтай базаж авна, энэ зовлон ч дуусна, ямар ч хэрэггүй нуугдах ч эцэс болно – гээд босч:

- Мөн ч харанхуй байна даа, хатан хааны гэрлийг асааж болохгүй. Сэм, чи үүнийг миний төлөө хадгалж бай. Би аваад хаанаа хийх вэ? Тернийг ч гэсэн чи ав Сэм. Надад орх кинжал байна. Тэгээд ч надад зэвсэг хэрэг болоо ч уу, үгүй ч үү.

Харанхуйд замгүй газраар, хад чулуун дундуур явах маш хэцүү байлаа. Гэвч мань хоёр алхам бүртээ бүдрэн урагшилсаар байв. Моргвейн баруун хажуугаар саарал гэгээ тусч, уулсын цаана өдөр болоход тэр хоёр нуугдах газар олоод ээлжээр унтав. Сэм сэрээд ямар ч гэсэн юм идэх хэрэгтэй гэж бодлоо. Фродо сайтар унтаж аваад сэрэхэд Сэм аль эртнээс хэлэн дээр эргэлдээд байсан идэх юмны тухай асуултаа тавилаа:

- Өршөөгөөрэй эзэн минь, одоо бид хэр их явна гэж бодож байна?

- Бодсон юм алга, Сэм, Уудам хөндийд байхад надад Мордорын газрын зургийг үзүүлсэн. Гэвч би бараг мартчихаж. Баруун болон хойт уулсын уулзвар газар байдгийг тод санаж байна. Цамхгийн дэргэдэх гүүрнээс нэг лиг /гурван бээр/ яваад зүүн зүг эргэх хэрэгтэй. Гэхдээ уулнаас хол, тэр хүртэл жаран бээр явах хэрэгтэй. Бид хоёр гүүрнээс арван хоёр гаруй лиг явсан. Яаж ч хичээгээд ууланд долоо хоног явна. Ууланд ойртох тусам бөгж хүндрэх учир удаан явна гэсэн үг.

- Миний бодсоноор л байна. Тэгвэл одоо усны тухай ярихаа байя гэхэд маш бага идэх хэрэгтэй болж байна. Одоо хурдан явж энэ хонхроос гаръя. Эльфийн талхнаас жаахан үлдсэн.

- Би хурдан явахыг хичээнэ ээ. За, жаахан юм идье.

Тэр хоёр харанхуй ч болоогүй байхад хөдөлж, шөнөжин явахдаа гурав дөрвөн удаа л амьсгаа дарж амсхийв. Дөнгөж үүр хаяарангуут том хясааны хөмсөг дор нуугдан амарлаа. Энэ удаа өрнийн хүчтэй салхи Мордорын дээгүүрх хар үүлэн бүрхүүлийг хөөж холын бараа харагдахтай боллоо.

- Гүйцээ, Сэм, хаашаа ч гарах зам алга. Өмнө маань орхын цамхаг байна, тэрний доогуурх замаар явахаас өөр арга алга. Ямар буцалтай биш. Баруун тийш зам байхгүй, зүүн тийш буух аргагүй.

- Замаар бол замаар, эзэн минь. Гэнэт бид хоёрт аз тохиож ч магадгүй. Арагшаа буцах юм уу, уул хадаар мацаж байснаас орхуудын саварт орсон нь дээр. Үнэгүй хоол өгнө, өөрснийх маань дуусч байна. Оролдоод үзье, гараад явчих ч магадгүй!

- За, Сэм, итгэл найдвар чамайг орхиогүй байгаа бол түрүүлээд яв. Намайг орхисон. Би араас чинь л салгалъя

- Хамтдаа л явна, эзэн минь. Харин эхлээд та жаахан юм идээд, түр унтаж амар. За, үүргэвчинд маань юу үлдэж вэ, үзнэ ээ.

Сэм дашмагаа Фродод өгөөд, аяны талхаа хувааж, өөрийнхөө хувийг Фродод нэмж өгөв. Тэгээд цуваа тайлж, дэр хийж өгөв. Туйлдсан Фродо дашмагт үлдсэн усыг бүгдийг нь ууснаа анзаарсангүй, Сэмийн хувийг идснээ ч мэдсэнгүй. Фродог унтсаны дараа Сэм түүний амьсгалахыг чагнаж, царай руу нь харж байснаа:

- За, эзэн минь, юу л болвол болог! Би таныг нэг цаг орхихоос яахав. Дахиад аз таарах байлгүй дээ. Усгүйгээр хол явахгүй – гэж бувтнав.

Сэм жинхэнэ хоббит маягаар нуугдан, үхэр хаднуудын дундуур гүйв. Голдрил руу орж, нэгэн цагт хүрхрээ байсан бололтой харагдах хойт талын хясаануудыг чиглэв. Тэнд одоо хуурай, нам жим байсан ч Сэм тун удаан, шургуу хичээн чагнасаар эцэст нь усны бүдэгхэн шоржигнох чимээ сонсов. Тэгээд хясаа өөд мацаж, нүцгэн хадан хажуугаар урсч байгаа горхийг оллоо. Сэм уснаас амсч үзээд сэтгэл хангалуун толгой дохиж, ханатлаа ууж аваад дашмагаа дүүргэлээ. Фродогийн унтаж байгаа хясаа руу эргэж хартал дэргэдүүр нь нэг хар сүүдэр шиг юм бөртгөнөж үзэгдэх нь тэр. Сэм эгээтэй л хашгирчихсангүй, бул чулуу дамжин гүйлээ. Нөгөө сүүдэр дахиж харагдаагүй боловч юун сүүдэр болохыг Сэм сайн мэдэж байлаа. Тэрнийг багалзуурдаж алах юмсан гэхээс тэсч ядаж байв. Гэвч сүүдэр түүнийг харчихаад зүүн хавцал руу орж алга болов.

- Алга болох нь ч алга боллоо. Золтой л эзнээ алдчихсангүй. Бид хоёрт зуун мянган орх багадаад энэ өмхий нэмэгдэж байгаа юм байх даа! Орхууд тэрнийг харвачихаж яагаад чадаагүй юм бол? – хэмээн өөртөө үглэв.

Фродог сэрээсэнгүй, өөрөө унтчихгүйг хичээсээр нүд өөрийн эрхгүй анилдахад сэрээв.

- Хорлум дахиад л эргэж шиншлээд байна. Би усанд явж байгаад эргэж харсан чинь тэр тан руу мөлхөж байна. Унтаж болохгүй шүү, би жаахан зүүрмэглээдэхье.

- Юу гэсэн үг вэ, Сэм! Хэвтээд сайн унтаж ав. Хорлум юу ч биш, орхууд л ирэхгүй бол болох нь тэр.

- Сэрэмжтэй байгаарай, эзэн минь! Дашмаг дүүрэн ус байна, уугаарай. Дараа замдаа дүүргэчихнэ.

Тэгээд Сэм нам унтав. Сэрэхэд харанхуй болсон байлаа. Фродо хадан хана налан суугаад унтаж байв. Дашмаг нь хов хоосон. Хорлумын бараа сураг ч алга. Хоббитуудыг замдаа гарахад уулан дээрх манааны галууд улалзаж байв. Горхинд хүрч, тэндээс зам руу гарлаа. Изенмаут хүртэл элбэг хорин бээр байв. Нарийхан зам хясааны ирмэг даган явсаар ёроолгүй ангалын дээгүүр үргэлжлэв. Арван хоёр орчим бээр яваад зогслоо. Нэгэн эгц эргэлтээр өнгөртөл замын үлэмж хэсэг нь харагдахаа болилоо. Эндээс л адал явдал эхэллээ. Хэсэгхэн зуур амраад цааш хөдөлтөл хамгийн их айж байсан чимээ гарав. Цэргүүдийн тахтай гутал түр тархийж, эргэлтийн цаанаас бамбарууд гэрэлтэж харагдав. Орхууд их хурдан явж байсан бөгөөд замаар тэднээс зугтах тухай бодох ч хэрэггүй байлаа.

- За баригдлаа даа, Сэм. Мордорт хэнд ч аз тохиодоггүй юм байна – гээд Фродо эгцхэн гилгэр хясаа руу харснаа замаар хөндлөн гүйж гараад харанхуй ангалын дээр сууж:

- Ингээд баригдлаа!

- Тиймэрхүү л юм болох шиг. Одоо яахав дээ, хүлээж л байя, юу болох нь вэ – гээд Сэм эзнийхээ дэргэд суув.

Удаан хүлээсэнгүй. Орхууд гүйлдэн ирэв. Эхний эгнээ нь бамбар барьж, галын улаан хэлнүүд улам ойртлоо. Тэр хоёр хөлөө бамбайгаар хаагаад нүүрээ нуун тонгойж суулаа. “Яарч яваа юм байна, ядарсан хоёр цэргийн дэргэдүүр гүйгээд өнгөрч магадгүй!” – гэж Сэм бодов. Яг л тэгэх гэж байлаа. Орхууд толгойгоо унжуулан аахилан гүйцгээнэ. Хар эзэн дайнд жижиг амьтдыг оруулж байгаа учир тэд хурдхан дайтах газраа хүрэхээр яарахаас гадна ташуурын амт үзмээргүй байв. Хоёр талаар нь хоёр аварга биет урукхай хашгиран гүйж, ташуураа тачигнуулна. Бамбартай цэргүүд хажуугаар нь өнгөрөн одож, Сэм амьсгаа түгжин хүлээв. Отрядын тэн хагасаас цөөхөн нь үлдлээ. Гэтэл хөөж явсан хоёрын нэг нь замын хажууд хоёр цэрэг сууж байгааг гэнэт үзчих нь тэр. Ташуур тасхийн исгэрч, зэрлэг дуу хэрээ мэт гуагалав:

- Хөөе, та хоёр! Босоод!

Хоббитууд дуугараагүй учир тэр отрядыг зогсоов.

- Жагсаалд хурдан ороод, нялцгайнууд аа! Залхуурна гэнэ ээ? – хэмээн тэр зандарснаа ойртож ирээд бамбай дээрх тэмдгийг үзэв.

- Аа, муу оргодлууд уу? Зугтаах нь уу? Манайхан өчигдрөөс хойш Удунд оччихоод байна! Та хоёрт тушаал хүргээгүй хэрэг үү? Жагсаалд хурдан ор, тэгэхгүй бол, дугаарыг чинь хуулж аваад илтгэнэ шүү!

Мань хоёр босч, хөлөө холгосон цэргүүд шиг хазганан жагсаалын араас шогшив.

- Тэгэхгүй шүү, тэгж ярихгүй! Гурван эгнээ урагш ор! Хоцрохгүй, би шалгана, тэгээд л гүйцээ!

Толгой дээгүүр нь урт шилбүүр исгэрч: “Гүйгээд маарш”.

Сэм тэртэй тэргүй хөл дээрээ арайхийн тогтож, Фродо хар даран зүүдэлж байгаа юм шиг байв. Тэр шүдээ зууж, юуны ч тухай үл бодон, яаж ч байсан гүйгээд л байхыг хичээв. Орхуудын хөлсний муухай үнэр амьсгаа давчдуулж, ам нь туйлгүй их цангаж байлаа. Аль болохоор жигд амьсгалж, хөлөө түргэн зөөхийг хичээв. Хаашаа гүйж байгаа, юу хүлээж байгаа тухай бодох ч сэхээ алга. Зугтах тухай бол бүр ч бүтэхгүй.! Хөөгч орх байн байн тэр хоёрт дээрэлхэхээр хоцорсхийнэ.

- Гүйгээд, гүйгээд! – хэмээн хөхөрч, хөл рүү нь ороолгон:

- Чадахгүй бол ташуурдаад өгье! Цовоо явна шүү, нялцгайнууд аа! Дайнд явж байгаагаа мартаа юу? Сануулаад өгнө өө!

Хэдэн бээр тасралтгүй гүйв. Фродогийн тамир барагдаж, зүрх зориг нь мохлоо. Тэр байн байн бүдэрч, Сэм өөрөө сүүлчийн хүчээ шавхан гүйж байсан ч эзэндээ дэм өгч байлаа. Хаанаасаа тийм их хүч гардаг юм бүү мэд. Тэгээд үхэхэд бэлтгэж байв. “Эзэн одоохон ухаангүй унаад өгнө, тэгээд бүх юм тодорхой болно, бүх юм дуусна. Энэ муу хөөгчийг ч би нүд ирмэх зуурт зүйл дуусгана” – гэж тэр бодож байв.

Тэгээд илднийхээ бариулыг атгатал санамсаргүй санаа нь амрав. Отряд Карак-Ангренy хавцал руу тулж иржээ. Гүүрнээс баруун, өмнө, зүүн тийш гурван зам салжээ. Бүх замаар цэрэг цувж байв. Хар эзэн бүх хүчээ Удунд татаж байгаа аж. Харуулын гэрэл хүрэхгүй газарт хэд хэдэн отряд өөд өөдөөсөө гүйж, бүгд л урагшаа тэмүүлэн, түлхэлцэж, хараал тавьцгааж байв. Хөөгчид орилж хашгиран, шилбүүрээ тачигнуулсаар байсан ч зодоонгүй өнгөрсөнгүй. Илд жад хангинан хавиралдаж байв. Барад-Дурын хуягт урукхайчууд тэдний отрядыг дайран жагсаалыг нь задрааж орхив.

Сэм гэнэт ухаан орох шиг болж, азтай тохиолдлыг алдалгүй газарт нам унахдаа Фродог татаж унагав. Орхууд тэр хоёрт бүдэрч, хараал тавьсаар гүйлдэн өнгөрнө. Хоббитууд эхлээд мөлхөж, дараа нь дөрвөн хөллөн харайсаар замаас гарч, далангийн цаана гарч дөнгөв. Зам уул өөд өгсчээ. Тэр хоёр хэвтэж амьсгаа дарав.

- Эзэнтээн! Жаахан холдье, тэгээд амраарай – гэж Сэм шивнэв.

Фродо хамаг хүчээ шавхан тохой дээрээ өндийгөөд тавиад алхам мөлхөөд, тэр хоёрыг хүлээж байсан юм шиг гүн биш нүх рүү өнхрөн оров. Тэгээд ухаан алджээ.

Бүлэг 13

Галт уул

Сэм орхын навгаснуудыг тайлж хаяад, эзэндээ дэр хийж, дээрээс нь лориэний саарал цуваараа хучив. Тэрхэн зуурт алс эльфийн хязгаар санаанд нь орж, ид шидийн хүчит энэ нөмрөг бид хоёрыг хамгаална гэж бодлоо. Орхуудын зодоон дуусч, орилолдоон нь намжжээ. Бүгд Изенмаут руу орсон бололтой. Тэр хоёрыг одоохондоо хэн л санаж гэж. Сэм уснаасаа балгаж, нойрмог Фродод балгуулаад, эзэн нь ухаан ороход аманд нь бүтэн пуглиб талх зуулгав. Хоёулаа айхыг үл хэрэгсэхээр ядарсан тул амрахыг л хичээж байв. Гэвч тайван унтаж чадсангүй, хөлсөнд норсон хувцас нь хайрч, дороос нь чулуу хатган тав муутай унтлаа.

Хүйтэн саарал өглөө боллоо. Сэм нүхнээс шагайж харав. Ойрын зам хоосон байсан боловч Сэм Изенмаутын хэрмийн соргог харуулуудаас айж байлаа. Зүүн өмнө талд Галт уул хар сүүдэр мэт сүглийж байна. Тэндээс бөөн бөөн утаа олгойдож, дээш хөөрсөн нь зүүн зүг рүү хуйлран нүүж, үлдсэн нь бэл, хөндийг бүрхэж байв.

- Тавин бээр хүрэхгүй юм бол би хоббит биш болог, бүтэн долоо хоног явах юм байна, ноён Фродог яаруулах аргагүй – гэж тэр урамгүйхэн бувтнав.

Тэгээд толгой сэгсрэн бодож байтал нэг бараан бодол торж ирэв. Урьд нь тэр хоёр нэг минут ч цөхөрч байгаагүй, хаа ч хүрсэн буцах зам байсан. Гэтэл одоо гарах зам алга. Зорьсон газраа хүрэх найдвар бараг байхгүй ч гэсэн хүрчихэж болох л юм. Гэвч тэгээд л бүх юм дуусна. Явах газар ч алга, идэх юм ч алга. Хаашаа ч харсан явах замгүй.

“Ийм юмтай хутгалдаж дээ. Уг нь шалихгүй ажил. Ноён Фродог үхэхэд нь тусална, далимд нь өөрөө хамт үхнэ. Ийм л юм болж дээ. Голын хөндийгөө дахиад харахгүй, Роза Кроттон, түүний ах дүү нарыг, аавыгаа харахгүй нь л харамсалтай байна даа! Гэндальф байсан бол ноён Фродог зайлшгүй үхэл рүү явуулахгүй л байсан даа. Тэр л Мориин нүх рүү унаснаас хойш ийм юм болчихлоо. Тэр байсан бол заавал нэг юм бодож олох байсан даа”.

Гэвч Сэм итгэл найдвараа алдаж байгаа юм шиг мөртөө алдсангүй. Харин ч шинэ хүч сэлбэж авчээ. Түүний сайхан сэтгэлт хоббит царай нь хатуу ширүүн дүртэй болж, өөрөө тэр чулуунаас хатуу, гангаас ч бөх болж, уйтгар гуниг, ядрал зүдрэлийг ялж чадна гэдгээ мэдэж байв. Төгсгөлгүй мэт энэ зам мөдхөн төгсгөл болно гэдгийг ч мэдэж байлаа.

Тэрбээр эргэн тойрныг шинэ нүдээр харж, цааш яаж явахаа бодлоо. Гэгээ ороход тэр хөндий огт тэгшхэн биш, нэлдээ ухагдсаныг анзаарав. Хаашаа л харна, том том нүхнүүд, эргэн тойронд нь овоолсон чулуу, суваг шуудуунууд. Нүхнээс нүхэнд дамжин хэний ч нүдэнд харагдахгүй яваад байж болох юм байна. Харин явах хүч тэнхээ л хэрэгтэй. Тэгж бодоод Сэм эзэн дээрээ очив. Фродо манант тэнгэр өөд харан хэвтэж байлаа.

- Эзэн минь, би сая эргэн тойрныг харлаа. Зам дээр хэн ч алга. Одоо эндээс зайлах хэрэгтэй. Та юу гэж бодож байна?

- Явна, би тийм үүрэгтэй.

Тэгээд мань хоёр нүхнээс нүхэнд дамжин мөлхөх газар мөлхсөөр, эргэн харсаар холдлоо. Зүүн зам нэг хэсэг тэр хоёрыг дагаснаа хажуу тийш эргэж, харанхуй хөндий рүү могой мэт мурилзан алсалжээ. Хөндийд орхууд ч, хүмүүс ч үзэгдсэнгүй. Хар эзэн бүх хүчээ умар зүг рүү хаясан, өөрийнхөө цамхгийг улам бэхлэн хаасан байлаа. Хар утаан үүлийг нь сарниан хөөж байгаа дайсагнагч салхи, Мордорт нэвтэрсэн их зүрхт тагнуулуудын тухай мэдээ түүнийг айлгаж байгаа нь илт. Хоббитууд дахин нэг бээр урагшлав. Фродо арай ядан мөлхөхдөө мөлхөж, гүйхдээ гүйж байвч ийм маягаар газар хороохгүй шинжтэй.

- Эзэн минь, гэрэлтэй байгаа дээр зам дээр гарья. Дахиад аз таарахыг хэн байг гэхэв! Замаар хэдэн бээр газрыг зүгээр л алхаад өнгөрнө шүү дээ.

Тэр хоёр далан дээр мацаж гараад, Барад-Дурын замаар хэвнэг алхав. Аз болох нь ч болж, харанхуй болтол зам дээр нэг ч амьтан гарч ирсэнгүй. Дараа нь тал дээгүүр харанхуй бүрхэж нуугдах хэрэгцээгүй болов.

Дөрөв хоног ийнхүү явлаа. Сүүлчийн өдөр Фродо нэг ч үг дуугарсангүй, замаа ч харалгүй, бүдчин алхана. Эзэнд нь хичнээн хүнд байгааг, бөгж түүнийг хэрхэн газар руу чангааж байгааг Сэм ойлгож байлаа. Фродо бүхнийг харагч нүднээс хаацайлж байгаа юм шиг байн байн зүүн гараа өргөж байхыг Сэм түгшүүртэй ажиглаж байв. Заримдаа баруун гар нь цээжин дээгүүрээ тэмтэрч, бөгжний гинжнээс барьснаа хатан зориг нь далдын хүчийг дийлэн гараа буулгаж байв.

Хурдан харанхуй болж, Фродо толгойгоо хоёр өвдөгнийхөө хооронд хийж, гараараа газар тулан, хуруунууд нь сарвалзан суулаа. Сэм тас харанхуй болтол түүнийг өрөвдөн харж байв. Эльфийн талх байгаагүйсэн бол аль хэдийн нүд аних байлаа. Тэр хүнс зөвхөн тамир тэнхээ сэлбээд зогсохгүй, сэтгэл санааг өөд татаж байв. Цаашид замаар явж болохгүй, одоо эргэх хэрэгтэй гэж далдын совин нь Сэмд хэлээд байв.

- Ус хэрэгтэй, ус! – гэж Сэм өөртөө хэлэв.

Одоо дашмагт нь дундаас доогуур ус үлдсэн бөгөөд дахиад хоёр гурван өдөр хуурай, хоосон газраар явах хэрэгтэй байв. Ямар ч шийд бодож ололгүй Сэм маргааш болтол хойшлуулахаар шийдэж, унтлаа. Хорсолтойгоор ёлтолзох гал, ямар нэг мөлхөө сүүдрүүд нүдэнд нь харагдах шиг, араатан амьтны дуу дуулдах шиг, сэрээд харахаар харанхуйгаас өөр юу ч байхгүй. Нэг удаа үнэхээр цийлгэр цайвар гэрэлт нүд харагдахад тэр босон харайв. Гэвч нүд алга боллоо.

Арайхийж түгшүүрт шөнө өнгөрөв. Фродо унтсаар. Сэм түүнийг сэрээмээргүй байсан ч сэрээхээс өөр арга байсангүй.

- Сэрээрэй, эзэн минь! Замдаа гарья.

Ухасхийн боссон боловч Уул руу харснаа толгой гудайв.

- Үгүй ээ, Сэм, би хүрч чадахгүй нь. Надад маш хүнд байна, ямар их хүнд байна аа – гэж тэр

дуугарав.

Сэм хариу хэлэх гэснээ юу ч хэлээд нэмэргүй гэж мэдмэгц хэлээ хазлаа. Эзэн нь үнэхээр өрөвдөлтэй харагдаж байв.

- Эзэн минь би таныг үүрээд явъя. Чадлаа хүрэх газарт хүртэл үүрье. Та жаахан амраад ав.

Фродогийн нүд хилэнтэй гялалзав.

- Надаас холд! Надад бүү гар хүр! Энэ бөгж минийх. Зайл – хэмээн хашгираад кинжаалаа шүүрэв. Тэгснээ дахин толгой гудайж:

- Үгүй ээ, Сэм. Чи ойлго, чи ойлгох ёстой. Энэ бол миний ачаа, би үүнээс хоромхон зуур ч салж чадахгүй. Миний хайрт Сэм, чи нэг удаа надад тусалсан. Дахиад болохгүй. Би энэнийг чамд өгч болохгүй, чи энэнд гар хүрвэл би галзуурна.

- Би ойлгож байна аа, гэвч эзэн минь, энэ илүү ачаанаас салъя л даа. Бид хоёр одоо шууд явж байна – гээд уул руу зааж:

- Хэрэггүй юмыг энд хаячихсан ч болно шүү дээ.

Фродо уул руу дахин харав.

- Тийм ээ, тэгвэл бидэнд бараг юу ч хэрэггүй. Энд бараг хэрэггүй, тэнд оччих юм бол бүр хэрэггүй.

Тэр орхын бамбай, дуулгаа аваад шидэж орхив. Тэгээд саарал цуваа тайлж, хутга зүүсэн хүнд хар бүс, хар навгаснуудыг ч тайлж хаяв.

- За ингээд болоо. Орх байж үзлээ, одоо болно. Би ямар ч зэвсэг агсахгүй. Дайсныхыг ч, өөрийнхийгөө ч. Баларвал ингээд л баларъя.

Сэм ч бас орх хуяг дуулга, хувцасны тамтгаас салж, үүргэвчээ ухав. Хичнээн их юм үүрч гарсан, бүгд ямар их хэрэг болж байлаа! Гэтэл одоо юу ч байдаггүй. Хоолны хэрэгслээ бодоход бүр нулимс нь урсав.

- Чанасан молтогчинг санаж байна уу, эзэн? Тэр уулын энгэрт, ноён Фарамир биднийг олсон шүү дээ?

- Үгүй ээ, Сэм. Санахгүй байна. Өөрөөр хэлбэл тэр бүхнийг би мэдэж байна, гэхдээ төсөөлөн бодож чадахгүй байна. Би алимны амт, усны амтыг санахгүй байна. Салхи яаж үлээдэг, мод, цэцэг, од, сар ямар байдгийг санахгүй байна. Харанхуйд миний нүдэнд зөвхөн галт цагариг л харагдаад байна. Би түүнийг нүдээ нээсэн ч, аньсан ч хараад байна, бусад бүх юм алга болчихсон юм шиг.

- Тэрнийг чинь л янзалчихъя, тэгээд амраарай.

Тэр хаясан зүйлүүдээ цуглуулангаа “Ажил хэрэгт амаар тусалж чадахгүй. Ингээд ил орхичихвол хэн ч харчихаж мэднэ. Өмхий хуяг авсан гэсэн, илд авах юу ч биш. Илдгүй ч гэсэн аймшигтай араатан шүү. Муу хар бузар, сав суулганд минь гар хүрчихээгүй байгаа?” – гэж бодов.

Тэгээд утаа савсч байгаа, нүх рүү очиж, бүх юмаа боож шидэв. Сав суулганых нь дуу жингэнэхэд тэр бараг л зүрх нь зогсчих шиг болов. Фродо руу хүрч ирээд, эльфийн олсноос хэрчимийг тасалж, эзэндээ бүс хийв. Дахиад зөндөө урт олс үлдэхэд нямбайлан эвхээд үүргэвчиндээ буцааж хийлээ. Ингээд олс, аяны талхны үлдэгдэл, дашмаг л үлдэв. Терн илд бүсэнд нь зүүлттэй, Галадриэлийн аяга болон жижигхэн хайрцаг өвөрт нь байлаа.

Тэгээд уул чиглэн нуугдалгүй ил алхав. Эндхийн бүх юмыг нүд мөрдөж байгаа ч гэсэн дэргэд ирэхгүй л бол бараг харахгүй биз. Хар эзний үй олон зарц нараас зөвхөн далавчит сүгнүүд л хориотой орны гүн рүү ухралтгүй дотогшилсоор байгаа хоёр жижиг дайсныг харж чадах байв. Гэвч тэднийг хар эзэн өрнөдийн цэргийн өөдөөс явуулсан, Барад-Дурын нүд ч тийшээ л харж байлаа.

Эзэнд нь энэ өдөр хоёр дахь амь ирсэн юм шиг Сэмд санагдаж байв. Тэр хоёр шууд л хурдлан алхаж, ууланд аяндаа дөтөлсөөр байв. Гэвч орой болоход бүдэг гэгээ харанхуйлан, Фродо дахиад л бөгтийж, бараг алхах бүртээ бүдрэх болов. Сүүлчийн амрах газарт ирэхэд тэр газарт суунгуут “Юм уумаар байна, Сэм” – гээд дахиж дуугарсангүй. Сэм түүнд дашмагтаа байгаа сүүлчийн балга усыг өглөө. Тэр өөрөө уруулаа ч чийглэсэнгүй, харанхуй нөмрөхөд усны тухай л бодож байлаа. Төрөлх нутгийнх нь гол, горхи, булгууд нүдэнд нь харагдаж, усны чимээ чихнээс нь салахаа байж, найз Джолли, Том, Нибс тэдний дүү Роза нартай хамт усанд шумбаж байх шиг.

- Өнөөдөр ч дажгүй шүү, бараг замын хагасыг туулчихлаа. Дахиад нэг өдөр явахад хүрнэ дээ – гэж тэр хэлээд цааш нь ярих юм олдсонгүй.

- Чи битгий тэнэглээд бай, Сэм Скромби – гэж өөрийнх нь дуу сонсогдов:

- Энэ бослоо гэхэд дөрвөн хөллөж л явах байх. Өнөөдрийнх шиг нэг өдөр боллоо гэхэд чи яах юм бэ? Байгаа усыг чинь энэ уучихна, байгаа талхаа энэнд бүгдийг нь өгчихөөд, өөрөө хоосон явж байгаа болохоор чи хаашаа зайлах юм бэ?

- Би хаачих вэ дээ, явах газар руугаа л явна.

- Хаашаа?

- Уул руу, өөр хаашаа байдаг юм.

- Тэнд очоод яах юм бэ, Сэм Скромби, яах юм бэ? За, хүрлээ гэж бодъё, тэгээд юу хийх юм бэ? Энэ өөрөө юу ч хийхгүй шүү дээ.

Сэмийн урам хугарав. Нээрэн тэнд очлоо гэхэд юу хийхээ огт мэдэхгүй байв. Фродо түүнд хэлж өгөөгүй, Сэм бөгжийг гал руу шидэх ёстой гэсэн бүдэг төсөөлөлтэй байв.

- Аа, Галт нүх рүү хаяна гэж Гэндальф ярьж байсан байх аа, тэр нүхийг яаж олохоо эзэн мэдэж байж магадгүй юм, би мэдэхгүй.

- Тэгж л таарна! Шал дэмий юм гэж энэ өөрөө ч гэсэн яриад байгаа биз дээ. Тэнэг чи юундаа найдаж, яах гэж зүтгээд байгаа юм бэ. Арай ухаантай байсан бол зүгээр л унтаад хэвтэж байхгүй юу. Албал ална л биз, яадаг юм, тэрнээс ч муу юм болвол яана. Зүгээр л тэрнийг намаг руу шидчихээд унтаад өг. Оргилд тэртэй тэргүй хүрэхгүй.

- Хүрнэ ээ, ясаа чирээд хүрнэ, бусад нь хамаагүй. Ноён Фродог хүрэх газарт нь хүргэнэ. Ямар ч байсан хүргэнэ, наад яриагаа боль!

Тэгтэл газар доргин чичирч, бүүр гүнд нь ямар нэг юм нүргэлэн уулан дээр улаан гал дүрэлзэв. Уул ч бас тайван биш байгаа ажээ.

Маргааш орой нь харанхуй болох үеэр тэр хоёр Ородруйны бэлд хүрэв. Фродогийн амьсгал нь давчдан унаад өглөө. Сэм дэргэд нь суув. Тэр маш их ядарсан боловч гайхалтай нь бие хөнгөн, толгой сэргэлэн байлаа. Одоо өөртэйгөө маргах юм байсангүй. Юу ч боллоо гэсэн тэр амьдралын төлөө биш, үхлийн өөдөөс сонголт хийсэн. Бүр нойр ч хүрсэнгүй. Бүх аюул, аймшиг нэг болон бөөгнөрсөн, маргааш тэр хоёрын хувь заяаг сүүлчийн дайралт шийднэ.

Гэвч маргааш болох юм болов уу? Цаг хугацаа зогссон юм шиг. “Нөгөөдөх чинь бас харанхуйгаа илгээсэн юм шиг байна, одоо өглөө болохгүй байх” – гэж Сэм бодов. Фродогийн гараас барьж үзтэл бүр бээрчихсэн байв.

- Хөнжлөө хэрэггүй хаяжээ – гэж Сэм бувтнав. Тэгээд Фродог өөр рүүгээ шахан тэврээд ямар ч гэсэн унтав. Аян замынхаа сүүлчийн өдрийн үүрийн гэгээг тусахад тэр хоёр тэврэлдэн унтаж байлаа. Өрнийн салхи намдаж, умрын ширүүн салхи үлээж, үл үзэгдэх нарны туяа хоббитуудын унтаж байгаа хонхорт тусч байв.

* * *

- За! Ингээд сүүлчийн дайралт! – гэж Сэм өөртөө хэлээд босов. Фродог сэрээлээ. Фродо ёолж, бүх хүчээ шавхан босоод, тэр дороо суув. Нүдээ арайхийн өргөж Галт уулын бүрхэг хажуу өөд хараад дээш мөлхлөө. Сэм хойноос нь хараад зүрх нь цусаар дүүрсэн боловч нүд нь хуурай байв.

- Үхэж байлаа ч гэсэн үүрээд гарна гэж хэлсэн биз дээ! Тэгэх ч болно... – гэж өөртөө хэлснээ:

- Эзэн минь, тэрнийг чинь авч явж болохгүй ч гэсэн таныг тэрэнтэй хамт үүрч болно биз дээ? Сэм таныг хүргээд өгнө, хаашаа явахыг л хэлээд өг!

Сэм Фродог үүрээд бостол тийм ч хүнд биш байсанд гайхав. Эзнийг ч үүрч даана, харин хараалт бөгж бид хоёрыг газарт няхах байх гэж бодож байсан ажээ. Тэгсэнгүй. Фродо үзэж туулсан бүхнээсээ болоод тэгж их турсан юм уу, Сэм гэнэт их хүч орсон юм уу, бүү мэд. Сэм нэг гүнзгий амьсгаа аваад уул өөд зүтгэв. Уулын баруун хойт бэлд тулж ирэхэд энэ тал нь нэлээд налуу хэвгий байлаа. Фродо хаашаа явахыг хэлээгүй боловч Сэм дахиж асуусангүй,

аль болохоор дээш гарья гэж л бодов. Тэгээд өгсөн өгссөөр, сүүлдээ унан тусч, хүнд хуягтай яст мэлхий шиг мөлхөв. Эцэст нь хөл гараа мэдрэхээ болиход эзнээ газарт буулгав.

Фродо нүдээ нээж, амьсгаа дарав. Өндөр газарт амьсгалахад хөнгөн, хар утаа бэлд хоцорчээ.

- Баярлалаа чамд. Сэм, Одоо хэр хол байна?

- Мэдэхгүй ээ, би хаана очихоо мэдэхгүй шүү дээ.

Сэм эргэн тойрноо харахад их өндөрт гарч ирсэн нь илт байв. Холоос нэгэн сүрлэг оргил ганцаараа өндөр юм шиг харагдаж байвч Эфель-Дуатын даваанаас хавигүй намхан байлаа. Ойролцоогоор бэлээсээ дээш гурван мянган алхам, түүний дээр орой нь тасарсан конус хэлбэрт оргил нь бас мянга таван зуу орчим алхам нэмэх бололтой. Сэм замын хагасаас илүүг туулж, Горгоротын хөндий тэртээ доор манарч байна. Тэр дээшээ хараад хоолой нь хатаагүй байсан бол хашгирах байлаа. Царцсан хайлц, бутарсан асганы цаана ямар нэг жим харагдаж байв. Тэр жим уулыг баруун талаас нь ороон оргил өөд зүүн талаас нь авирчээ. Сэм дээшээ авирвал жим дээр гарцаагүй хүрэх юм байна гэж мэдлээ.

Сэм гунигтайяа санаа алдав. Зам харагдаад байдаг, гэтэл энэ эгц хажуугаар яаж тэнд хүрэх вэ? Тэгээд Фродогийн хажуугаар хэвтлээ. Хоёулаа дуугарсангүй. Тэгж байтал арай гэгээтэй боллоо. Гэнэт Сэм нэг л ойлгомжгүй сэтгэл түгшиж эхлэв. Хэн нэгэн: “Хурдлаарай, түргэлээрэй, тэгэхгүй бол оройтно!” – хэмээн дуудах шиг. Тэр бослоо. Фродо ч тэр дуудлагыг сонссон бололтой, эргэж, түрүүлгээ харав.

- Би мөлхөнө өө, Сэм.

Мань хоёр хоёр саарал цох мэт дээш мөлхсөөр хайрга, үнсээр өнгөлсөн өргөн замд хүрэв. Фродо зам хүрээд зүүн зүг рүү удаанаар эргэж харлаа. Алсад тэнгэрээс газарт хүртэл зурвас харанхуй хөшиглөсөн байв. Хар салхи дэгдэж байгаа юм уу, Саурон ямар нэг юмнаас айж болгоомжилсон юм уу, хар хөшиг хоромхон зуурт Барад-Дурын дээд цамхгийн төмөр титэмт оройг ил татан гаргав. Тэнгэрийн доорх цонх гялсхийж, умар зүг рүү улаан туяа харвалаа. Галт нүд харанхуйг нэвтэлж байгаа нь тэр агаад хоёр хоббитыг биш, Мордорын хаалгын өмнө зүгт байгаа өрнийн дайчид руу харсан байжээ. Гэвч энэ аймшигт хоромд Фродо үхлийн нүд рүү харжээ. Гар нь бөгжний гинжийг салгалан тэмтчиж эхлэв.

Сэм дэргэд нь суулаа. Фродо дөнгөж дуулдах төдий шивнэв:

- Надад туслаарай, Сэм! Сэм, туслаарай! Миний гарыг барьж бай, би гараа тогтоох хүч алга.

Сэм эзнийхээ гарыг барьж алгандаа атгав. “Мөрдөөд харчихаж. За одоо тэсэх цаг боллоо доо. Хөөрхий Сэммиум Скромби ч баригдлаа даа” - гэж тэр бодов. Гэвч Фродог босгож нуруун дээрээ унагаад хоёр гараас нь барьж, замаар дээш өгсөв. Явахад их хэцүү байв. Аз болоход уулнаас тургисан галан урсгал өмнөд болон баруун хажуу руу урсч байсан тул зүүн хойт талд зам бүтнээрээ байлаа. Сэм аахилан зүтгэж байтал хясаан дээрээс нэг хар юм дээрээс нь унаж байгааг нүдний булангаар үзэв. Сэм зайлж амжсангүй, эзнийхээ гарыг тавилгүй түрүүлгээ унахдаа гараа шалбалав. Тэгмэгц юу болсныг ойлголоо. Толгой дээр нь хараал

идсэн гуншаа дуу гарав:

- Өөдгүй муухай эзэн! Өөдгүй муухай эзэн биднийг хуурчээ, Смеагорлыг хуурлаа, горлум. Наашшшаа явж болохгүй шшшүү. Эрдэнийг минь гомдоож болохгүй. Алив, нааш нь өгөөтөх, Смеагорлд, бидэнд байжжж байг!

Сэм ухасхийн босч илдээ сугалсан боловч илдний хэрэг болсонгүй. Горлум, Фродо хоёр зууралдан өнхрөлдөж байв. Хорлум бөгжинд хүрэх гэж эзнийг нь хумсаараа урж байлаа. Гэтэл Фродо улайран тэмцэлдэж, Сэмийг ч, Хорлумыг ч гайхашруулав. Хорлум урьдынхаараа байсан бол энэ тэмцэл яаж дуусах нь тодорхойгүй байв. Гэвч тэр зовлонт тэнэмэл мөнхийн өлсгөлөн, цангаа, айдас, амь тэмцүүлсэн гунигаасаа болоод арьс яс хоёр л үлджээ. Фродо түүнийг хөсөр шидэж орхиод хамаг бие нь чичрэн босч ирэв.

- Тонил, тонил! – хэмээн цамцны цаанах бөгжөө атгаад:

- Замаас зайл, мөлхөө шавьж! Чи дууссан. Одоо чи намайг алж ч чадахгүй, худалдаж ч чадахгүй.

Тэр хоёр нэгэнт огт өөр болсныг Сэм харлаа. Амьдын төдий, ялагдсан, гэвч хорсол дүүрэн хэвээрээ шуналт өчүүхэн амьтан цагаан өмсгөлт сүрлэг эзний хөлд атиралдаж байна. Эзний цээжинд галт хүрээ гялалзаж, тэндээс сүрдэм чанга, захирангуй дуу хадав:

- Тонил, над руу бүү ойрт! Дахиад надад хүрэх юм бол Галт нүх рүү шидэж орхино шүү.

Хорлум няц гишгүүлсэн хорхой мэт атиралдан ухравч үл цавчих нүдэнд нь айдас, нөгөөх л хэмжээлшгүй гуниг дүүрэн байв.

Энэ үзэгдэл замхрахад Фродо хүндээр амьсгалан, гараа цээжиндээ наан зогсч, Хорлум урд хоёр мөчөөрөө газар тулан эвхэрч байгааг харав.

- Болгоомжтой! Тэр тан руу үсрнэ шүү! – хэмээн Сэм илдээ далайгаад:

- Түргэлээрэй, эзээн! Яв, яв! Цаг дууслаа. Би энэнийг аргална. Яв!

Фродо түүн рүү холоос харж байгаа юм шиг хараад:

- Тийм ээ, би явах хэрэгтэй. Баяртай, Сэм! Одоо үнэхээр бүх юм дууссан. Хувь тавилан Галт уулан дээр үгээ хэлнэ. Баяртай !

Тэгээд цааш эргэж, замаар оргил өөд өгсөн алхав.

- За! Одоо чамтай тооцоо бодно доо! – гээд илдээ далайн ойртоход Хорлум өөдөөс нь дайрсан ч үгүй, зугтаасан ч үгүй, түрүүлгээ харан хэвтээд гаслав.

- Намайг алах хэрэггүй! Биднийг муухай хүйтэн төмрөөр тасчих хэрэггүй. Бидэнд дахиад жааахан, бүүр жааахан амьдрах хугацаа өг. Үхххэл, үххэл, бидэнд үхэл л үлдлээ. Эрдэнэ алга болно, бид хумхийн тоос болно, тийм ээ тоооссс.!

Сэмийн гар чичирсхийв. Тэр их хилэгнэсэн, энэ хорт аалз хичнээн гай тарьсныг мэднэ. Урвагч, алуурчинг цавчих хэрэгтэй. Тэр ийм шийтгэлийг зуун удаа ногдуулахаар хэрэг хийсэн. Өөрөөр үүнээс яаж хамгаалах юм бэ? Гэвч сэтгэлийн гүндээ Сэм ингэхгүй гэж, хорвоо дээр хоргодох юу ч үгүй, өчүүхэн амьтныг алахгүй гэдгээ мэдэж байв. Тэр өөрөө бөгжийг түр зуур хадгалж байсан болохоор бөгжний боол болсон энэ өөдгүй амьтан яаж тарчилж байгааг мэдэж байв.

- Өмхий бузар минь, тонил! Алга бол, бүү үзэгд! Би чамд хумсын чинээ ч итгэхгүй, гэлээ ч гэсэн алга бол! Тэгэхгүй бол муухай хүйтэн төмрөөр тас цавчина шүү.

Хорлум дөрвөн хөллөж, дараа нь босч, зугтаав. Сэм тэрнийг тэр дорхноо мартлаа. Фродо зам дээр харагдаагүй учир араас нь байдаг хүчээрээ яаран өгслөө. Хэрэв эргэж харсан бол Хорлум араас нь хар сүүдэр мэт хад чулуу дамжин гэтэж байгааг харах байв. Зам улам өгсүүр боллоо. Дахин зүүн тийш эргээд, дараа нь хавцал дундуур Саммат-Наурын хаалга болсон агуй руу оржээ. Сэм агуй руу шагайж харав. Уулын гүнээс халуун харанхуй дүнгэнэж байв.

- Фродо! Эзээн! – гэж дуудав. Хариу алга. Сэм жаахан зогсоход зүрх нь тэсэхийн аргагүй айдас дүүрэн тонгочиж байв. Хажуугаар нь хар сүүдэр сүүтгэхийн өнгөрлөө.

Эхлээд юу ч харагдсангүй. Сэм Галадриэлийн аягыг гаргаж ирэхэд чичирсэн гарт нь дөнгөж бүдэгхэн гэрэлтэв. Тэр Сауроны эзэмшлийн зүрхэнд байгаа болохоор Дундад газарт хамгийн агуу хүчирхэг эртний энэ голомтод харанхуй хаанчилж байлаа. Урагшаа хэд алхтал гэнэт урдаас нь өндөр хар нуман хаалга гараад ирэв. Сэм урт агуйд орж ирснээ ухаарлаа. Агуйн хана, шал нэлдээ хагарч цуурсан, завсраар нь байн байн гал дүрсхийж, галт уулын гүнд асар хүчтэй машинууд ажиллаж байгаа мэт нүргэлнэ.

Агуйн ханаар дахиад гал улалзахад хүрэн улаан гэрэлд ёроолгүй гүн галт тогооны амсар дээр Фродо зогсч байгаа үзэгдлээ.

- Эзээн! - гэж Сэм хашгирав.

Гэтэл Фродо Галт уулын нүргээнийг дарсан сүрлэг чанга, захирангуй, огт танил биш дуугаар:

- Би ирлээ. Гэхдээ төлөвлөснөөсөө өөр юм хийнэ. Бусдын санааг би няцааж байна. Бөгж минийх!

Тэр бөгжийг хуруундаа углаад үзэгдэхгүй болов. Сэм цөхрөн хашгиртал ар нуруу руу нь хүчтэй цохилт бууж, унахдаа толгойгоороо чулуун шал мөргөөд ухаан алдав. Энэ хоромд өөр олон үйл явдал болж өнгөрлөө.

Харанхуй хязгаарын зүрх болсон Саммат-Наурт бөгжний шинэ эзэн гарч ирэхэд Барад-Дурын эзэн цочин татвагасхийж, баг бэх цайз нь уулын бэлээс титэмт оройгоо хүртэл доргин чичрэв. Хар эзэн гэнэт санаа авч, бүхнийг харагч нүд нь харанхуйг нэвглэн, тал хөндий дээгүүр Мордорын эзний эрхэм нандин агуйн хар ам руу тэмүүлэв. Хар эзэн дайснуудынхаа бүх тооцоог ухаараад, өөрөө ямар тэнэг алдаа гаргаснаа цахилгаан цахих мэт хурдан ойлголоо. Түүний уур хилэн түймэр мэт дүрэлзэн, айдас нь бөөн хар үүл мэт хуйлрав. Энэ

мөчид түүний хувь тавилан хутганы ирэн дээр байгааг тэр мэдэв.

Тэр өөрийнхөө бүх хар санаа, хар хорын үйл, дайн байлдаан, айдас, заль мэх... бүгдийг мартав. Түүний хязгааргүй уудам эзэмшил тэр аяараа доргиж, боолууд нь айдаст авгаж, их цэрэг нь яах ч учраа олохоо байж, захирагчид нь зэвсгээ хаялаа. Хар эзэн тэр бүхнийг мартсан байлаа. Тэрний хамаг санаа Галт уул руу чиглэв. Бөгжтөн хар сүүдрүүд байлдааны талбараас Ородруин руу хойно урдаа орон нисч одов.

* * *

Сэм өндийлөө. Толгой нь эргэж, нүдэнд нь цус хуржээ. Нүдээ арчаад хартал хачирхалтай юм үзэгдэв. Ёроолгүй галт ангальн ирмэг дээр Хорлум хий хоосонтой тулалдаж байв. Тэр нэг ангальн ирмэгт тулж, нэг холдон, унан тусч, эвхрэлдэнэ. Нэг ч үг хэлэхгүй, зөвхөн хорсолтой шуухитнан амьсгаадах ажээ.

Ангальн гүнд гал буцалж, хуйхлах шахам халуун агаар цоргиж, агуйг хүрэн улаан гал улалзан гэрэлтүүлж байлаа. Гэнэт Хорлумын урт гар ам руугаа сунаж, хурц соёо нь гялсхийв. Фродо дуу алдан хашгираад ангальн ирмэг дээр өвдөг сөхрөн суусан харагдлаа. Хорлум тас хазсан хуруутай бөгжийг дээш өргөн, ангальн ирмэг дээр галзуу мэт цовхчин харайж байв. Бөгж нарнаас ч хурц туяатай харагдана.

- Эрдэнэ минь, эрдэнэ минь, эрдэнэ минь! Миний эрдэнэ! Өө Миний эрдэнэ! – хэмээн Хорлум баярласандаа байдгаараа орилно. Тэгээд гэрэлтэж буй эрдэнээ нүдээрээ залгих шахан цоо ширтсээр хальт гишгэж, ангальн ирмэг дээр ганхан гуйвснаа “Эээ-ррдд-ээн-эээ!” – хэмээн хашгирах дуу нь гараад Хорлум алга боллоо..

Галт уул нижигнэн нүргэлж, ангалаас бөөн бөөн гал агуйн адарт тулан оволзлоо. Тэр нүргээн үргэлжилсэн их цууриа болж, уул доргин чичрэв. Сэм Фродо руу ухасхийж, гараас нь шүүрээд агуйн хаалга руу гүйлээ. Саммат-Наурын хар босгоны цаана, Галт уулын орой дээрээс Мордор орон тэр чигээрээ харагдаж, Сэм айсан, гайхсандаа хөшиж орхив.

Барад-Дур байсан газарт галт шуурга хуйларч, тэр дундаас уулсаас өндөр цамхгууд, хөрөөний ир шиг ирмэгт хана хэрэмнүүд, цонхгүй нүсэр том шоронгууд, төмөр хаалганууд агшин зуурт үзэгдсэнээ бүгд алга болов. Цамхаг, хана хэрэмнүүд нуран унаж, уулс дэлбэ үсэрч, гал утаа тэнгэрт олгойдож харагдав. Нижигнэж, тачигнаж, хүржигнэсэн их чимээ үргэлжлэн нүргэлэв. Газар энд тэндгүй хагарч байлаа. Ородруин овехийн доргиж, орой нь тас үсрэн, галаар урсав. Аянга нирхийж, цахилгаан тэнгэрийг ороолгон, харанхуйлсан аадар асгарав. Газар тэнгэрийн хоорондох галан шуурга руу хар үүлсийг хага яран, аймшигтай чарлалдсаар хар сум мэт чавхдан орж ирсэн бөгжтөн хар сүгнүүд нүд ирмэх зуурт дүрэлзэн, үнс болон замхарлаа.

- Тийм байна, энэ үнэхээр төгсгөл мөн байна, Сэм Скромби - гэх дуу хажууд нь гарахад эргэж харвал царай нь цав цагаан болж, туйлдаа хүртэл ядарсан ч тайван зогсч буй Фродо байлаа. Түүний харцанд үхлийн айдас, солиорлын аль нь ч байсангүй. Түүний хүнд ачаа алга болж, тэр Хоббитанидаа байгаа юм шиг, өнгөрсөн гэгээн өдрүүдээ бодож байв.

- Эзэн минь! - гэж Сэм хашгираад өвдөг сөхрөн унав. Тэрбээр ертөнц сүйрч байгааг мартаад, баяр хөөрөөр бялхан байлаа. Тэр аймшигт дарамт байхгүй болсон, эзэн аврагдсан, тэр өөрийнхөөрөө болж, чөлөөлөгдлөө! Сэм эзнийхээ нэг хуруугүй болж, цус урссан гарыг харав.

- Хайран гар! Боох ч юм алга, эм ч алга. Ингэхийн оронд миний нэг гарыг тасдаад хаячихгүй. Гэвч одоо тэрнээс гуйлтай биш, одоо тэрнээс үнс ч үлдээгүй.

- Тийм ээ, Гэндалф нэг удаа: “Хүлээж бай, Хорлум яагаад ч юм дахиад хэрэг болно” гэж хэлснийг санаж байна уу? Хэрэг боллоо шүү дээ. Би өөрөө устгаж чадахгүй байсан, бид хоёр зорьсон газраа ирсэн боловч бүх юм талаар өнгөрөх байсан. Түүнийг муугаар дурсаад яахав! Даалгавар биелсэн, чи надтай хамт байгаад би бүхнээс илүү баяртай байна. Ингээд бид хоёрын үлгэр энд төгслөө дөө, Сэм.

Бүлэг 14

Кормаллены талд

Эргэн тойронд Мордорын цэрэг далай буцлах мэт оволзоно. Өрнөдийн цэрэг тэрхүү зах хязгааргүй далайд живж байлаа. Хүрэн улаан нар бүдэгхэн гэрэлтэж байсан ч түүний туяаг үхлийн сүүдрээ газарт унагаж байгаа үхдэл сүгнүүдийн далавчнууд хааж байлаа. Арагорн тугийнхаа дэргэд өнгөрсөн өдөр хоногуудын тухай бодож байгаа юм уу, алс хязгаар нутгийн тухай бодож байгаа юм уу бүү мэд, таг дуугүй мөртөө ширүүн дүртэй зогсох бөгөөд нүд нь харанхуйд гэрэлтэх од мэт гялалзан авай. Уулын орой дээр цасан цагаан өмсгөлт Гэндальф зогсох бөгөөд хар сүүдрүүд түүнд үл хүрэх аж. Мордорын цэрэг уулнаас бөөн бөөнөөр өнхрөн холдох авч улам улайран дайрсаар, улангассан орилоон, зэвсгийн харшилдаан нь улам чангарч байлаа.

Гэндальф гэнэт ямар нэг хий үзэгдэл үзсэн мэт цайвартах тэнгэрийн умар зүг рүү харцаараа тэмүүлснээ хоёр гараа өндөр өргөн, аянга хүржигнэх мэт чанга дуугаар тулалдааны чимээг дарж:

- Бүргэдүүд нисч ирлээ! Бүргэдүүд! – хэмээн хашгирав.

Тэгтэл мордорын боолууд, хөлснийхөн, гар хөл бологсод тэнгэр өөд алмайран ширтэв.

Тэнгэрт умард хязгаарын агуу бүргэдүүд - Салхин жигүүр болон түүний дүү Хурдан жигүүр тодрон гарч ирэв. Тэр хоёр бол Дундад газар идэр залуугийн баяр хөөрөөр бялхан байх цагт Хязгаарын уулын хэн ч хүршгүй оргилд үүр юугаа зассан Торондорын үр удам билээ. Тэр хоёрын араас умардын уулсын төрөл садангууд нь хүчирхэг эгнээгээрээ харвасан сум мэт хурдлан ойртов. Тэд далавчит сүг сүүдрүүд рүү шууд дайран ороход өргөн жигүүрүүд нь шуурга мэт шуугин исгэрэх нь сонсогдов.

Гэвч сүг сүүдрүүд Хар цамхгаас нэн яаралтай дуудлага авсан тул огцом эргэж, Мордорын харанхуйд далд оров. Тэрхэн хоромд Мордорын далай мэт их хар цэрэг гэнэт балмагдаж, зэрлэгээр хөхрөлдөхөө болиод, гар нь чичрэн, барьсан зэвсгээ алдаж харагдав. Тэднийг урагш хөөж, үзэн ядалт, галзуурлаар дүүргэж байсан тэр хүч гэнэт алга болоход хар цэргүүдийн нэгдмэл омог нь суларч, тэд дайснуудынхаа нүднээс үхлээ олж харжээ.

Өрнөдийн цэрэг харанхуйн гүнд зурсхийсэн шинэ найдварын гэрлээр жигүүрлэн, баяртайгаар уухайлан, бүслэгдсэн уулан дээрээс Гондорын явган цэргүүд, Ристанийн морьт дайчид, Умардын баатар вангууд эгнээ эгнээгээрээ дайсны цэргийн дундуур зүсэн орлоо. Гэвч Гэндальф дахин гараа өргөж, тулалдааны чимээг дарсан их дуугаа хүнгэнүүлэн:

- Зогсоорой, Өрнөдийн дайчид аа! Азнаарай! Эцсийн цаг цохиж байна! – гэж хашгирав.

Түүнийг ийнхүү хэлж дуусаагүй байхад газар дэлхий аймшигтай доргилоо. Хар хаалганы цамхгуудын дээгүүр, бүрэнхий уулсын дээгүүр доороосоо галаар хөөрөгдүүлсэн хязгааргүй их харанхуй газраас тасран хөөрөв. Газар дэлхий ёолон чичирнэ. Мордорын соёонууд

дайвалзан ганхаснаа нуран унаж, хүчирхэг цайзууд баг бэх хаалганууд хоромхон зуурт үнсэн товрог болж, чих дөжрөм их их нүргээн болов.

- Сауроны хаанчлал дууслаа! Бөгж хадгалагч даалгавраа биелүүлжээ – гэж Гэндальф зарлав.

Өрнөдийн цэргүүд өмнө зүг рүү харлаа. Мордорт асар том хар сүүдэр хөөрч, захаар нь аянга цахилгаан гялбаж байснаа ширүүн салхинд замхран алга болов. Эргэн тойрон бүх юм нам гүм боллоо. Далай шиг давалгаалан оволзож байсан дайсны их цэрэг хумхийн тоос мэт хуйлран алга болж байгааг өрнөдийн дайчид гайхан харав. Шоргоолжны үүрэн дотроос тэр тоо тоомшгүй олон шоргоолжийг удирдан чиглүүлж байсан нууц хүчин сөнөхөд шоргоолжнууд хандсан зүг рүүгээ бутран тардагтай адил Сауроны шоргоолжнууд болох орхууд, троллууд, бусад араатнууд зарим нь амиа хорлож, зарим нь хаашаа ч хамаагүй таран гүйж, нүх сүв болгон руу шургаж байлаа. Харин вастакууд, Руны болон Хородын галзуу зэрлэг дайснууд эртний өстөн Өрнөдийнхний ихэмсэг бардам байдлыг хараад ялагдсанаа мэдэж, тулалдаанд үхэхээр эгнээгээ засч байлаа. Гэвч тэдний ихэнх нь зэвсгээ хаян бууж өгч, зарим нь дорно зүг рүү эргэж ч харалгүй зугтав.

Гэндальф Арагорн болон бусад жанжингуудад тулалдааныг дуусгахыг тушаагаад өөрөө уулсын орой дээрээс бүргэдүүдийг дуудахад агуу бүргэд Гвайгир Салхинжигүүр бууж ирэв.

- Чи намайг хоёр удаа аварсан, Гвайгир анд минь, одоо сүүлчийн удаа туслаач гэж би гуйж байна. Миний өмнөх амьдрал шатаж үнс болсон Зиракзигилаас ниссэн шиг би чамд их тээр болохгүй – гэж Гэндальф хэлэхэд:

- Хэрэгтэй л юм бол би чамайг ертөнцийн хязгаарт ч хүргэнэ.

- Тэгвэл нисье, дүүгээ дагуул, бас замд хоцрохооргүй нэг бүргэд дагуул. Яагаад гэвэл бид ямар ч салхинаас хурдалж, хар сүгнүүдээс түрүүлж очих ёстой.

- Умардын салхи хүчтэй ч гэсэн бид түүнийг давна – гэж Гвайгир хэлэв. Тэр Гэндальфыг нуруун дээрээ суулгаад өмнө зүг рүү харвасан сум мэт хурдлахад араас нь Хурданжигүүр, идэр залуухан Менельдор хоёр даган нисэв. Тэд Удун, Горгоротын дээгүүр нисэн өнгөрөхөд өмнө нь Галт уул дүрэлзэж харагдав.

* * *

- Сэм минь ээ, чи надтай хамт байгаад чинь би ямар их баярлаж байна аа. Ингээд бид хоёрын үлгэр энд дуусч байна даа – гэж Фродо өгүүлэв.

- Мэдээж, би тантай хамт байхгүй өөр хаана байх билээ - гээд Сэм Фродогийн шархтай гарыг цээжин дээрээ тавьж:

- Та ч гэсэн надтай хамт байлгүй яах билээ, тийм ээ, аялал маань дуусч байх шиг байна. Харин нэг юмыг л ойлгохгүй байна. Яваад л байсан, яваад л байсан, тэгээд ирэнгүүтээ үхэх гэж үү? Энэ ч манайхны зан биш дээ.

- Яая гэхэв дээ, Сэм. Тэгдэг л юм байна. Хамаг итгэл найдвар эцэс болно, бид ч гэсэн тэдэнтэй хамт. Одоо дахиад жаахан, тэгээд л болоо. Энэ аймшгийн эргүүлгэн дотроос бид хоёр яаж амьд гарах вэ дээ!

- Юу үнэн бэ, тэр үнэн байх шүү эзэн минь, гэхдээ л энэ хонхроос холдье. Хөл чинь одоохондоо байрандаа байгаа биз дээ? Явья эзэн минь, ашгүй зам одоохондоо бүтэн байна!

- За за, тэгвэл явья, Сэм минь. Чи хаашаа, би тийшээ.

Тэр хоёр босч, дөнгөж доошоо эргэтэл Саммат-Наур асар том өтгөн утаа харвав. Галт уулын орой доош сууж, халуун хайлшийн буцалсан улаан урсгал зүүн хажуугаар нүргэлэн бууж байлаа. Ингээд зам хаагдах нь тэр.

Фродо, Сэм хоёр сүүлчийн хүчээ шавхаж байлаа. Яаж ийгээд бэлийн ойролцоох овоорсон нурманд хүрсэн боловч цаашаа явах газар байсангүй. Эргэн тойронд газар хагаран гүн ангалууд үүсч, гал утаа олгойдно. Уул оволзтол доргин халуун хайлш цацалж, тал талаас нь галын урсгал мөлхөн ойртож байв. Дээрээс нь халуун үнс бороо шиг асгарна. Тэр хоёр мөр зэрэгцэн зогсч, Сэм эзнийхээ гарыг тавилгүй атгаж байлаа. Тэр санаа алдав.

- Муугүй үлгэр байсан биз дээ, эзэн минь? Сонсох юмсан. Есөн хуруут Фродо ба бүхнийг захирагч бөгжний тухай туужийг сонсоцгооё гэхэд бүгд нам гүм болно. Яг л бид Уудам хөндийд ганц гарт Берен ба Шидэт Сильмариллын туужийг сонссон шиг. Сонсох юмсан! Бид хоёр эхнийх ч биш, эцсийнх ч биш, цаашдаа ямар нэг юм болж л таарна.

Тэр үхлийн өмнөх айдсаа даван ийнхүү ярьж байхад харц нь ширүүн салхи хүнд үүлсийг хөөж, тэнгэр цэлмэж буй тэртээ умар зүг рүү тэмүүлж байлаа.

* * *

Салхинаас түрүүлэн хурдалж ирсэн Гваигир Ородруины дээгүүр нэгэнтээ эргэж, үхэл тээсэн галт шуургыг бардамхан даваад бяцхан овгор дээр гар гараасаа барилцан зогсч байгаа хоёр жижигхэн хүнийг харав. Эргэн тойронд нь газар доргин хагарч, галан тэнгис хүрээлж байлаа. Бүргэд тэр хоёрыг хараад, чанх чиглэн доошлох мөчид нөгөө хоёрын хүч чадал нь барагдсан уу, утаанд хордсон уу, үхлээс нүдээ нуусан уу бүү мэд, зэрэг унаад өгөв.

Гваигир Салхинжигүүр, түүний дүү Хурданжигүүр, зоригт Менельдор гурав шумбан доошилж, амьтай амьгүй алин болох нь тодорхойгүй хоёр аянчинг шүүрэн авч нуруун дээрээ тавиад гал, утаанаас авч гарлаа.

* * *

Сэм зөөлөн орон дээр сэрэв. Түүний дээр дал модны өтгөн мөчир найгаж, навчсын завсраар нарны туяа тусч байлаа. Анхилуун агаар сэнгэнэнэ. Сэм энэ үнэрийг төвөггүй танилаа. Итилийн үнэр байна. “Ээ эцэг минь! Ингэж их унтах гэж байх уу!” – гэж бодов. Тэр нар туссан толгойн энгэрт гал түлж байснаа санав. Бусдыг нь таг мартжээ. Тэгээд суниаж, санаа алдав.

- Зүүдлэхгүй юм ч гэж алга аа! Сэрсэн минь сайн болов!

Орон дээрээ өндийж суугаад хартал хажууд нь Фродо унтаж байна. Зүүн гараа дэрлэж, баруун гараа хөнжил дээрээ тавьжээ. Баруун гарын дунд хуруу нь алга байв.

Ой дургал мэлсхийтэл сэргэж Сэм дуу алдав:

- Юуны чинь зүүд! Бид хоёр хаана ирчихэв ээ?

Дээрээс нь аяархнаар:

- Та хоёр одоо Итилид, эзэн хааны ивээлд байна. Эзэн хаан та хоёрыг хүлээж байна – гэх сонсдов.

Түүний өмнө цав цагаан өмсгөлтэй Гэндальф зогсч байх бөгөөд цасан цагаан сахлаас нь нарны туяа ойж харагдав.

- За, эрхэм Сэммиум, ажил хэрэг ямар байна даа?

Сэм цочин арагшаа унаад амаа ангайж, гайхсан, баярласандаа дуугарч чадахгүй байв. Эцэст нь арайхийж дуугарав:

- Гэндальф! Чамайг аль эрт үхсэн гэж бодож байсан шүү! Гэхдээ би ч гэсэн бас л амьд байх ёсгүй юм шиг. Тэр бүх аймшиг огт байгаагүй юм шиг. Ер нь юу болсон юм бэ?

- Ертөнцийг нөмөрсөн хар сүүдэр сарнисан – гээд Гэндальф инээхэд түүний инээд хөгжим шиг, хагаж хагарсан газраар горхи урсч байгаа юм шиг сонсогдов. Сэм энэ инээдэнд ер бусын их баяр хөөрийг мэдэрч байлаа. Тэгээд асгартал уйлав. Түүний нулимс хаврын бороо шиг асгарч, борооны дараа нар хурцаар ээж, газар дэлхий сэргэдэг шиг цангинатал инээгээд босон харайв.

- Миний ажил хэрэг ямар байна гэж үү? Мэдэхгүй байна аа, ер нь ... өвлийн дараа хавар болдог шиг, дулаан нар навчнуудыг нахиан дотроос нь дуудаж гаргадаг шиг, бүх бүрээ зэрэг үлээдэг шиг – гээд түгдэрч Фродо руу харснаа:

- Харин ноён Фродо? Гарыг нь гэмтээсэн! Гэхдээ ганц хуруу л даа, бусад нь бүрэн бүтэн. Энэ хүнд л хамгийн хэцүү байсан даа!

- Бусад нь бүрэн бүтэн, Сэм, - гээд Фродо инээн босч орон дээрээ суугаад:

- Чи ч нойрны тулам юм аа, Сэм, би чамайг харсаар байгаад өөрөө унтчихаж, өглөө сэрсний хэрэг гарсангүй. Одоо үд болоо биз.

- Үд болсон гэнэ ээ? Ямар өдрийн үд дунд?

- Өнөөдөр шинэ эриний арван дөрөвний үд болж байна. Хоббитанийн тооллоор бол дөрөвдүгээр сарын найман. Гондорт бол шинэ эриний гуравдугаар сарын хорин таван.

Сауроны сөнөсөн өдрөөс шинэ эриний тоолол эхэлсэн, та хоёрыг гал дундаас аварч, эзэн хаанд авчирсан. Хаан та хоёрыг эмчилсэн, одоо хүлээж байна. Хаантантай үдийн зоог барина. Хувцсаа өмс, би хүргэж өгнө.

- Хаан гэнэ ээ? Тэр чинь юун хаан билээ - гэж Сэм асуув.

- Гондорын их ван бөгөөд бүх баруун газрын эзэн хаан. Тэр эргэж ирээд эртний хаант улсаа сэргээн байгуулж байна. Мөдхөн хаан ширээндээ заларна. Та хоёрыг хүлээж байна.

- Юу өмсөх вэ – гэж Сэм, орны хөл доор хөглөрч байгаа уранхай цоорхой хувцас руугаа харав.

- Мордор руу орохдоо өмсч явснаа л өмс. Сахиус шиг хадгалж яваарай. Фродо, чи ч гэсэн орхуудын навтсаа өмс. Баруун болоод дундад газарт та хоёрын хувьд үүнээс илүү ямар ч эрхэм хүндтэй гоёл юу ч биш болно. Дараа нь бид та хоёрт өөр хувцас өгнө - гэж Гэндальф хэлээд гараа сунгахад алган дээр нь намуухан гэрэл цацрав.

- Тийм гэж үү? Чамд байгаа юм уу?... - гэж Фродо гайхахад.

- Тийм ээ, та хоёрын нандин эрдэнэс чинь. Сэм хадгалж байсныг олсон юм. Хатан хаан Галадриэлийн бэлэг. Чиний гэрэлт аяга Фродо, чиний хайрцаг Сэм. Май, баярлацгаа.

Хоббитууд яаралгүй гар нүүрээ угааж, хувцаслаад, хөнгөн хоол идчихээд Гэндальфыг даган гарав. Тэд гал улаан цэцэгтэй өндөр моддоор хүрээлэгдсэн өргөн нугад гарч ирэв. Хаа нэгтээгээс хүрхрээний чимээ хүржигнэж, өмнө нь цэцэг алагласан эргийн хоорондуур тунгалаг гол урсан нугын цаад талын төгөл рүү шургажээ.

Төглийн цаана гармагц тэр хоёр мэл гайхав. Наранд гялалзсан хуяг дуулгатай баатар вангууд, мөнгөлөг-хар хуяг дуулгатай өндөр өндөр харуулууд эгнэн жагсаад, тэдэнд мэхийн ёслол. Нэг нь урт бүрээ үлээж, манай гурав голын хажуугаарх замаар алхсаар өргөн ногоон дэвсэг дээр гарч ирэв. Алсад нимгэн манан дунд өргөн мөрөн мөнгөрөн гялалзаж, ойрхог урт арлын эргээр үй олон онгоцууд зогсч харагдана. Ногоон дэвсгийг цэргүүд хүрээлжээ. Хоббитууд дөхөж ирэхэд, илднүүд гялалзаж, бамбай дэлдэн, бүрээ цангинаж, бөмбөр нижигнэн, олон мянган хүний хоолой цууриалав:

Жижиг биетүүд мандтугай! Хамгаас өндөр магтаалыг тэдэнд өргөсүгэй!

Куйо и Перийан аннан! Аглар-ни перианнат!

Фродо, Сэммиум нарт агуу магтаал өргөсүгэй!

Даур а Бергаэль, Конин эн Аннун! Эглеро!

Алдар нь бадрах болтугай!

Эглеро!

А лайта те, лайта те! Андаве лаитувальмет!

Алдар нь бадрах болтугай!

Кормаколиндор, а лайта тариэнна!

Бөгж хадгалагчдын алдрыг магтая!

Фродо, Сэм хоёрын царай улайж, нүд нь гайхшралаар гэрэлтэн талбайд гарч ирээд харвал талбайн төвд гурван өндөр хаан суудал зассан байв. Баруун талын суудлын ард давхиж яваа морины дүрстэй цагаан-ногоон өнгөт туг, зүүн талын суудлын ард мөнгөн хунгийн дүрстэй хөлөг бүхий цэнхэр туг, голд нь байгаа хамгийн өндөр суудлын ард долоон од бүхий цагаан модны дүрстэй хар туг мандуулжээ. Тэр суудал дээр хуяг өмссөн их ван сууж байх бөгөөд өвдөг дээр нь аварга том илд тавиатай, толгой нүцгэн ажээ. Манай гурвыг дөхөж очиход их ван босч ирэхэд нь хоббитууд түүнийг танилаа. Тэрбээр бардам ихэмсэг, баяр хөөртэй байх бөгөөд урьдын адил бараан үс, саарал нүдтэй хэвээрээ байв.

Фродо түүний өөдөөс ухасхийхэд Сэм бага зэрэг хоцорсхийв.

- Энэ чинь хэн бэ! Чи тэнэмэл биш бол би хоббит биш болог!

- Тийм ээ, тэр чинь л байна. Би чамд таалагдаагүй Уулын суурингаас эхэлсэн зам их хол явах байжээ! Тийм ээ, бидэнд бүгдэд маань хэцүү байсан, тэгэхдээ чамд л хамгийн хэцүү байсан байх.

Дараа нь Арагорн Сэмийн өмнө өвдөг нугалан мэхийж мань хоббитыг гайхашруулж, бүр ичээж орхив. Тэгээд баруун гараараа Фродог, зүүн гараараа Сэмийг хөтөлж, хаан суудалд суулгаад дайчид, жанжингууд руу эргэж маш чанга дуугаар:

- Эдэнд агуу магтаал өргөгтүн! – гэж зарлиг буулгав.

Дайчдын сүрлэг магтаал цууриалаад өнгөрсний дараа гондор дуучин урагш давшин гарч ирээд тэдний өмнө өвдөг сөгдөж шинээр зохиогдсон дуу дуулах зөвшөөрөл хүсэхэд Сэм бүр мэл гайхаж, хэзээ ч баярлаж байгаагүй ихээр баярлав. Дуучин дуугаа эхлэхийн өмнө:

- Анхаараарай! Анхаараарай! Их баатар вангууд, удирдагчид, дайчид аа, Гондорын дайчид та бүхэн, Ристанийн морьт дайчид та бүхэн, Элрондын хөвгүүд та бүхэн, Умардын дунаданчууд, эльфүүд, гномууд та бүхэн, Хоббитанийн уужим сэтгэлт баатрууд та бүхэн, Баруун газрын бүх чөлөөт ард түмэн та бүхэн анхааран сонсоно уу. Би есөн хуруут Фродо болон бүгдийг захирагч бөгжний тухай дуулна.

Сэм үүнийг сонсоод чихэндээ итгэсэнгүй, баяртайяа чанга гэгч инээж, босон харайгаад:

- Гайхамшгийн гайхамшиг, хосгүй их алдар минь ээ! Би ийм юм болно гэж мөрөөдөж ч зүрхлээгүй билээ! – хэмээн хашгирав.

Бүх дайчид уйлж, инээж байсан бөгөөд тэдний дууг дуучны цангинасан чанга алтан, мөнгөн хоолой дарж байлаа. Эльфийн яриа, өрнөдийн аялга сонсогдож, дууны аялгуу зүрхийг тааламжтайяа шархлуулан, уй гашуу баяр хөөртэй холилдож, нулимс согтууруулж байв.

Нар тэнгэр голлоод баруун тийш хэлбийж, моддын сүүдэр уртсах үес дуучин дуугаа төгсгөлөө.

- Эдэнд агуу их магтаал өргөөрэй! – гээд дуучин өвдөг сөхрөн суув. Арагорн босч ирэхэд дайчид эгнээгээ задалж, зассан ширээнд сууцгаалаа.

Фродо, Сэм хоёрыг тусгайлан барьсан асарт оруулж, бохир, уранхай хувцсыг нь тайлуулан нямбайлж эвхэн авч явлаа. Оронд нь гоёлын шинэ хувцас өмсгөв. Гэндальф эргэж ирэхэд гарт нь байгаа умардын илд, эльфийн цув, мифриль хуягийг хараад Фродо мэл гайхав. Тэдгээрийг орхууд Мордорт хурааж авсан билээ. Сэмд алтадсан хуяг, цэвэрлэж, оёсон цувыг нь авчирч өгөөд хоёр илдийг нь өмнө нь тавилаа.

- Одоо надад ямар ч илд хэрэггүй - гэж Фродо хэлэхэд:

- Өнөө орой илдтэй байх ёстой - гэж Гэндальф хариуллаа.

Фродо Сэмийн кинжаалыг аваад:

- Терн илдийг чамд.

- Үгүй ээ, эзэн минь! Танд үүнийг ноён Бильбо энэ мөнгөлөг хуягтай хамт өгсөн. Хэрэв та хэн нэгэнд өгчихсөн байхыг мэдвэл тэр их гайхна.

Фродо түүний үгэнд орж, Гэндальф тэр хоёрын зарц цэрэг мэт бүсийг нь бүсэлж, илдийг нь зүүж өгөөд толгой дээр нь мөнгөн титэм тавив.

Тэгээд их найрын ширээнд морилж, Гэндальф, Ристанийн эзэн захирагч Эомер, Имраиль ван болон өрнөдийн бусад жанжингуудтай зэрэгцэн суув. Гимли, Леголас хоёр ч тэнд байлаа.

Бүгд босч баруун зүг харан дуугүй зогссоны дараа дарс аягалагч бололтой хоёр жижигхэн хөвгүүн хүрч ирэв. Нэг нь Минас-Тиритийн хамгаалагчийн мөнгөлөг-хар өмсгөлтэй, нөгөө нь цагаан - ногоон өмсгөлтэй ажээ. Сэм энэ агуу хүчирхэг вангуудын дунд хоёр жижигхэн амьтан яагаад ороод ирдэг байна аа гэж гайхсанаа ойртож ирэхэд нь таньж:

- Хараач эзэн минь! Энэ чинь Пин, үгүй ээ уучлаарай, ноён Перегрин Молтогчин, ноён Мерри хоёр байна! Ямар өндөр болоо вэ! Эцэг минь! Бид хоёроос гадна бас ярих юмтай хүмүүс байна шүү!

- Тийм ээ, Сэм, зөвхөн та хоёр биш – хэмээн Пин баяртай инээмсэглэж:

- Ёстой нэг яриад өгнө дөө, одоохондоо тэсч бай, найр жаргаг. Одоохондоо Гэндальфыг шалж бай, тэр одоо өмнөх шигээ нууцгай биш болсон, гэхдээ ярихаасаа инээх нь их болсон доо. Мерри бид хоёрт зав алга, бид хоёр чинь Гондор, Ристанийн вангууд учраас ажилтай байна.

Хөгжилтэй найр удаан үргэлжилж, нар жаргаж, Андуины манан дээгүүр сар хөөрөн гарч ирэхэд Фродо, Сэм хоёр анхилам тансаг үнэрт Итилийн моддын сэрчигнээн дор суугаад Мерри, Пин, Гэндальф, Леголас, Гимли нартайгаа бараг үүр цайтал хөөрөлдөв. Бусад

хадгалагчид Рэросын хүрхрээний ойролцоох Парт-Галенд зам салснаас хойш тэдэнд юу тохиолдсоноо бүгдийг ярьж өгөв. Орхууд, ярьдаг модод, төгсгөлгүй уудам ногоон тал, өнгө алаглан гялалзсан агуйнууд, цагаан цамхгууд, алтан оройт өргөөнүүд, аймшигт ширүүн тулалдаанууд, аварга том дарвуулт хөлөг онгоцууд гээд л – нэг үгээр хэлэхэд тэдний ярианаас Сэмийн толгой эргэж гүйцэв. Гэлээ ч гэсэн яриаг нь сонсох зуураа байн байн Пин, Мерри хоёр руу харж байснаа эцэст нь тэссэнгүй, Фродог босгож, тэр хоёртой нуруугаа нийлүүлэн чацуулж үзэв. Тэгээд шилэн хүзүүгээ маажлаа:

- Та хоёрын насан дээр өснө гэж баймааргүй л юм! Гэтэл лав гурван сөөм өндөр болчихсон байх юм, тэгвэл би гном болохоос!

- Чи гном болтлоо өстөл өдий байна - гэж Гимли хэлээд:

- Гайхаад байх юм алга, энэ хоёр онтуудын булгаас уусан байна шүү дээ, тэр бол чиний залгилдаг пиво биш!

- Онтуудын булаг гэнэ ээ? Та нар онт онт гээд л байх юм, тэд чинь хэн юм бэ, ойлгох юм алга. За яахав, дахиад нэг долоо хоног ярьсны дараа аяндаа ойлгох байлгүй дээ.

- Долоо хоног гэдэг чинь зөв, Минас-Тиритэд хүрээд Фродог цамхагт түгжчихье, бичихээсээ залхуурахгүй биз. Тэгэхгүй бол дараа нь талыг нь мартчихна, хөгшин Бильбо гомдож хоцорно шүү дээ – гэж Пин хэлэв.

Гэндальф босч:

- Эзэн хааны гарт эмнэх хүч байгаа андууд минь, та хоёр үхлийн саварт базуулчихсан байсан, хаантан хамаг хүчээ шавхан байж та хоёрыг тэр савраас гаргаж ирсэн. Та хоёр аврагдаад их удаан унтаагүй боловч нойр авсан юм шиг байна. Гэхдээ одоо унтах цаг болжээ.

- Сэм, Фродо хоёр ч мэдээжийн хэрэг, Пин чи ч гэсэн унтах хэрэгтэй. Чи надад төрсөн дүүгээс минь өөрцгүй, чиний ачаар би сунаж унатлаа гүйлээ, зуун жил ч мартахгүй. Тулалдааны дараа чамайг толгод дээрээс олсноо ч зуун жил мартахгүй. Гном Гимли байгаагүй бол чи одоо газар доор нойрсч байгаа. Гэхдээ би хоббитийн улыг юутай ч андуурахгүй. Харин тэгэхэд овоолоостой хүүрэн дундаас цухуйж байсан юм. Дээрээс чинь дарсан нүсэр том махыг авч хаяад нүүр рүү чинь харахад яах аргагүй үхчихсэн байсан. Би тэгэхэд харууссандаа арай л хууз сахлаа хуулаад хаячихаагүй. Одоо чи хөл дээрээ босоод ганцхан хонож байна. Явж унт, би ч гэсэн унтлаа.

- Харин би эндхийн сайхан ойгоор жаахан алчихаад амарна аа. Хэрэв Трандуил хаан зөвшөөрвөл ойн эльфүүдээс дуртай хэдийг нь дагуулж ирнэ, тэгвэл танай хязгаар улам сайхан болно. Ямар хугацаагаар гэж үү? Удахгүй ээ, нэг сар ч юм уу, нэг нас ч юм уу, хүний амьдралын бүтэн эрин ч юм уу. Үүгээр Андуин урсч, их усаа тэнгист юүлдэг. Тэнгист!

Цахлай шувууд эргэлдэн хашгирах тэнгис рүү!

Цахарсан хөөст давалгаан хурд нэмэх тэнгис рүү!

Харах нүдний үзүүрт шингэх наран туяарч байна.

Хөлөг онгоц минь, холын дуудлагыг сонсч байна уу?

Өөрөөсөө түрүүлж нисгэсэн дууг минь сонсч байна уу?

Өтгөн ой минь, баяртай, би явъя даа.

Өнгөрсөн өдрүүд одож, өөр эрин эхэлж байна.

Харин би тэнгисийн чинад одож өөр эрэгт очно.

Тэнд урт урт долгис эцсийн эргийг угааж,

Тэртээ мартагдсан аралд нарны шувууд чуулж,

Насны боолууд очдоггүй эльфийн нутаг Эрессед,

Навчис огт унадаггүй мөнхийн оронд амьдарна.

Ингэж дуулсаар Леголас уул руу буув.

Бүгдээрээ тарж, Фродо, Сэм хоёр унтлаа. Өглөө сэрэхэд энхрий намуухан өглөө угтаж, Италийн анхилуун үнэрт дөрөвдүгээр сар үргэлжилж байлаа. Кормаллены тал Хеннет-Аннунаас холгүй учир шөнийн цагаар хүрхрээнийх нь чимээ дуулддаг, хадан хавцал дундуур урсч байгаа голын чимээ ч дуулддаг, тэр гол Каир-Андрос орчмоор Андуинд цутгадаг билээ. Хоббитууд нэлээд хол явж, танил газруудаараа зугаалан, ойн аль нэг цоорхойд юм уу, хаа нэгтээ хонхорт аварга том олифантыг дахин нэг харах юмсан гэж мөрөөдөж байлаа. Минас-Тирит хэрмийн дэргэд тэд өчнөөн олон байсан, бүгдийг нь алаад шатаасан гэж сонсоод Сэм үнэнээсээ урам хугарав.

- Тийм дээ, нэг зэрэг хоёр газарт байж болохгүй, миний аз таарсангүй дээ – гэж тэр өгүүлэв.

Энэ хооронд их цэрэг Минас-Тирит рүү буцахаар бэлдэж байлаа. Дайчдын ядаргаа арилж, шархаа эмчилцгээжээ. Тарж зугтсан өмнөдийнхөн болон вастакуудын үйлдэгдлийг цэвэрлэх хэрэгтэй байлаа. Умард хэрмийг нь нураахаар Мордор руу илгээсэн дайчид ч эргэж ирэв.

Тавдугаар сар хаяанд ирж, өрнөдийн цэргийн жанжингууд хөлөг онгоцонд сууж, Каир-Андросаас Андуинаар хөвөн Осгилиат хүрээд түр саатсанаа маргааш нь Пеленнорын ногоон талд, өндөр сүрлэг Миндоллуины бэлд, шинэ эриний босгон дээр гал, угаан дундаас тэсч гарсан өрнөдийн сүүлчийн тулгуур – Гондорын нийслэлд ирэв. Тэд ногоон талд асар майхнаа босгож, тавдугаар сарын эхний өглөөг хүлээлээ. Эзэн хаан ургахын улаан нарнаар нийслэл хотдоо орно.

Бүлэг 15

Эзэн хаан

Гондорын нийслэл айдас хүйдэс дунд амьдарч байлаа. Өглөө болгон муу мэдээ хүлээж, найдах юм юу ч байхгүй болсон хүмүүсийг цэлмэг тэнгэр, хурц нар даажигнаж байгаа юм шиг санагдана. Эзэн захирагч нь өөрийгөө шатаачихсан, Ристанийн эзэн захирагчийн шарил өргөөнд хэвтэж байгаа, шөнө ирсэн шинэ эзэн хаан өглөө болоход байхгүй болсон, бүхнийг захирагч, хэнд ч, ямар ч хүчинд үл ялагдах харанхуй, аймшгийн хүчинтэй байлдахаар явсан сурагтай. Бүгдээрээ л ямар нэг мэдээ тэвчээртэй хүлээж байв. Цэргүүд Моргулийн хөндийгөөс хойт зүг рүү эргэсэн, тэгээд үхмэл уулсын хар харанхуй руу орсон гэдгийг л мэдэж байв. Дахиад тэндээс элч ирсэнгүй, ямар ч сураг чимээгүй.

Цэрэг хөдлөөд хоёр хоносны дараа хатан хаан Эовин хувцсаа авчир гэж асрагчиддаа тушаасан ба тэдний ятгалгыг огт хэрэгссэнгүй. Түүнийг хувцаслахад нь тусалж, шархтай гарт нь боолт хийгээд анагаах танхмын захирагчид хүргэж өгөв.

- Эрхэм эзэн минь, миний сэтгэл тайван биш байна, цаашид дэмий уйтгарлаж байх чадал алга – гэж тэр шулуухан хэлэв.

- Хатан хаантан, таны лагшин бүрэн эдгэрээгүй, надад эмчилгээг эцэст нь хүртэл туйлын нягт нямбай хий гэж хатуу тушаасан. Дахиад долоо хоног хэвтэх хэрэгтэй. Босч болохгүй байсан юм. Би танаас гуйж байна, буцаад анагаах өргөөнд морил – гэж захирагч эрс хэлэв.

- Би эдгэрсээн, зүүн гар л муухан байна, гэвч энэ юу ч биш. Харин юу ч хийхгүй гиеүрээд байвал бие муудна. Дайны талбараас мэдээ алга гэж үү? Би асрагч нараас асуусан ч тэд мэдэхгүй байна.

- Мэдээ байхгүй, манай цэрэг Моргулийн хөндийгөөс дайсныг цэвэрлээд цаашаа хөдөлсөн мэдээ л ирсэн. Манай цэргийг умардаас ирсэн шинэ жанжин захирч яваа гэсэн. Тэр бол агуу дайчин, бас дээр нь агуу анагаагч. Анагаагчийн гар илд эзэмшинэ гэж би бодож байсангүй. Манай Гондорт бүх юм өөр, эртний үлгэрт итгэх юм бол тийм тохиолдол байсан. Харин олон зууны туршид анагаагч бид илдний үлдээсэн шархыг л анагааж ирсэн юм. Үнэндээ энэ шархнуудгүйгээр бидэнд хийх ажил хангалттай их байна. Ертөнцөд хичнээн олон өвчин эмгэг байдаг билээ, гэтэл дээрээс нь энэ дайн байлдаан.

- Үгүй дээ эрхэм захирагч, ямар ч дайныг нэг тал нь эхэлж нөгөө тал нь аргагүйн эрхэнд хамгаалж байлддаг юм. Гэвч илд барихгүй бол илдэнд амиа алдана. Хар эзэн цэрэг цуглуулж байх хооронд Гондорын ард түмэн өвс ногоо түүж байхыг та хүсч байгаа юм уу? Нууцлах ямар ч шаардлагагүй тохиолдол ч байдаг. Зарим тохиолдолд тулааны талбарт хатуу ширүүн үхлийг хүлээж авах нь дээр ч байдаг. Хэрэв би өөрөө сонгох эрхтэйсэн бол тэр л үхлийг сонгоно.

Захирагч түүн рүү гайхан харав. Өндөр гоолиг, цонхигор царайдаа гялалзсан нүдтэй тэрбээр зүүн зүг рүү харсан цонх руу эргэж, эрүүл гарынхаа нударгыг зангидан зогсчээ. Захирагч

санаа алдан толгой сэгсрэв. Хатан хаан эргэж харлаа:

- Дэмий суугаад юугаа хийх вэ! Танай хотод одоо ерөнхий захирагч нь хэн байна?

- За мэдэхгүй дээ, хатан хаантан минь, миний мэддэг ажил биш. Энд үлдсэн мустангиримчүүдийг тэдний жанжин захирч байгаа, хотыг манай түлхүүр хадгалагч Турин мэдэж байгаа. Ер нь манай шинэ эзэн захирагч бол мэдээж Фарамир.

- Түүнийг хаанаас олох вэ?

- Түүнийг эрэх шаардлагагүй, тэр манайд эмчлүүлж байгаа, хүнд шархадсан, одоо илааршиж л байна. Харин...

- Тэгвэл намайг түүн дээр хүргээд өгнө үү, очоод мэднэ биз.

Фарамир анагаах танхимын дэргэдэх цэцэрлэгээр ганцаараа зугаалж байв. Нарны дулаахан туяанд бие нь бага зэрэг сэргэсэн боловч, сэтгэл санаа нь хүнд, байн байн зүүн хэрэм рүү очиж байлаа. Захирагч дуудахад эргэж хараад, Эовиныг үзэж, өрөвдсөндөө цочин агзасхийв. Хатан хааны шаналсан царай тун ч гунигтай харагджээ.

- Эзэнтээн, энэ бол Ристанийн Хатан хаан Эовин. Эзэн захирагчтайгаа хамт тулалдаж байгаад айхтар хүнд шархдаж, миний асаргаанд эмчлүүлж байгаа юм. Гэвч миний асаргаанд сэтгэл хангалуун биш байгаа учир тантай уулзана гэсэн юм – гэж Анагаах танхимын захирагч учирлав.

- Битгий буруу ойлгоорой эзэнтээн, би гомдол тавих гэж ирээгүй. Анагаах танхимд бүх юм дээд зэргийн сайн байгаа. Эмчлүүлж эдгэрэх гэсэн хүмүүст шүү дээ. Харин надад хий дэмий хэвгэх, хоригдох тэсвэрлэшгүй бэрх байна. Би тулалдаанд үхлийг хайсан боловч олсонгүй. Гэхдээ дайн дуусаагүй байгаа шүү дээ...

Захирагч Фарамирын дохиогоор мэхийн ёслоод явж одов.

- Чамд би яаж туслах вэ, хатан хаантан? Би ч бас анагаагчдынхаа асаргаанд хоригдож байна шүү дээ.

Фарамир дахиад түүн рүү харлаа. Бусдын уй гашуу ямагт түүний санааг зовоодог билээ. Хатан хаан өөрийнхөө уй гашуунд улам ч сайхан харагдаж, түүний гоо үзэсгэлэн зүрхийг нь шивэх шиг болов. Эовин бас нүдээ өргөж, түүн рүү дахин харав. Намуухан, энхрий харцтай мөргөлдлөө. Дайчдын дунд өссөн Эовин Ристани даяар хайгаад эн зэрэгцэх хүн олдохгүй баатар вангийн өмнө зогсч байгаагаа ойлгов.

- Чи чухам юу хүсч байгаа юм бэ, хатан хаантан? Ярь ярь, миний эрх мэдэл хүрэх л юм бол би бүгдийг хийнэ.

- Чи захирагчид намайг Анагаах танхимаас гарга гэж тушаагаасай гэж би хүсч байна – гэж тэр хэлэхэд үг яриа нь урьдын адил бардам сонсогдсон ч дуу хоолой нь чичирсхийж, амьдралдаа анх удаа өөрийнхөө хэлсэнд эргэлзэв. Эелдэг зантай мөртөө хатуу ширүүн нь илт

энэ өндөр дайчин өөрийг нь хөөрхий төөрсөн хүүхэд гэж бодож байх шиг байна, найдваргүй ч гэсэн эхэлсэн хэргээ дуусгах хатуу зориг хүрэлцэх болов уу? - гэж Хатан хаан бодов.

- Би захирагчид тушаах эрхгүй, би өөрөө түүний захиргаанд байгаа. Энэ хотод одоохондоо би эзэн биш. Гэвч бүрэн эрхт эзэн захирагч байлаа ч гэсэн эмчилгээний талаар эцсийн үгийг анагаагч хэлэх ёстой. Тийм биз дээ?

- Гэхдээ би эмчлүүлэхийг хүсэхгүй байна. Би дүү Эомертойгоо мөр зэрэгцэн тулалдаж, эзэн захирагч Теоден шиг үхмээр байна. Тэр баатарлагаар амь үрэгдсэн, мөнхийн алдар, мөнхийн амгаланг олсон.

- Чамд тийм хүч байлаа гэхэд манай цэргийг гүйцэх оройтсон. Тулалдаанд амь үрэгдэнэ гэдэг хүссэн ч, хүсээгүй ч биднийг бүгдийг хүлээж байдаг. Харин чи цагийг нь болтол эмчилгээгээ дуусгавал нэр төртэй, баатарлаг үхэлтэйгээ тулах болно. Бид хоёрт хүлээх хувь ногдсон, тэгэхээр тэвчээртэй хүлээх хэрэгтэй.

Эовин юу ч хэлсэнгүй, гэвч царай нь хаврын анхны бүлээн салхины үлээлтээс хахир хүйтэн ухардаг шиг арай зөөлөрчээ. Дусал нулимс борооны дусал шиг гялалзан хацар дээгүүр нь гүйлээ. Бардам тэргүүн нь ч бөхийв. Тэгээд хэнд ч хандаагүй юм шиг аяархнаар:

- Намайг дахиад бүтэн долоо хоног орондоо хэвт гэсэн. Миний цонх зүүн зүг рүү хардаггүй.

Тэрбээр гомдсон жаахан охин шиг ярихад нь хичнээн өрөвдөлтэй байлаа ч гэсэн Фарамир өөрийн эрхгүй инээмсэглэв:

- Цонх уу? Энэ ч харин засч болно шүү. Би захирагчид хэлье, тэр зохицуулна. Дуулгавартай эмчлүүл, хатан хаан минь, орондоо үргэлж хэвтээд байх хэрэггүй, нартай цэцэрлэгээр хичнээн ч зугаалж болно, эндээс зүүн зүг рүү хар, тэр зүгээс итгэл сүүмэлзэх нь уу, үгүй юу. Надад ч гэсэн сэтгэл арай хөнгөрнө, надтай хэдэн үг сольдог ч юм уу, зүгээр л хамтдаа алхаж болно биз дээ?

Тэр дахин толгойгоо өргөж, түүний нүд рүү хараад цонхигор хацар нь ягаарав.

- Яагаад хөнгөрнө гэж, эзэн минь? Би хэнтэй ч ярихыг хүсэхгүй байна.

- Чамд шууд хэлэх үү?

- Хэл.

- Тэгвэл, Ристанийн хатан хаан Эовин минь, чи өөрийгөө дэндүү сайхан бүсгүй гэж мэдэж ав. Манай энэ хөндийд гайхамшигтай сайхан цэцгүүд үй олноороо ургадаг, сайхан бүсгүйчүүд ч олон. Гэхдээ өнөөг хүртэл би Гондорт чамаас сайхан, чамаас сайхан бөгөөд гунигтай цэцэг ч үзээгүй, бүсгүйг ч хараагүй. Магадгүй, хэд хоногийн дараа газар дэлхийг харанхуй нөмөрч, үхэхээс өөр ямар ч гарцгүй болж ч мэднэ, гэвч нар унтраагүй цагт надад чамайг харах их сайхан байх болно. Би ч, чи ч ертөнцөөс гадуурх харанхуйд байж үзсэн, нэг л гар биднийг тэр үхлээс аварсан шүү дээ.

- Эзэн минь, энэ бол миний тухай яриа биш! – гэж Эовин яаран хариулаад:

- Харанхуй одоо ч гэсэн миний дээр нөмрөөстэй байна. Би анагаагч болж чадахгүй. Миний эвэршсэн гар илд бамбай хоёрт л тохирно. Гэхдээ чамд баярлалаа, Гондорын эзэн захирагчийн зөвшөөрлөөр цэцэрлэгээр чинь зугаалъя даа.

Тэр мэхийн ёслоод явахад Фарамир цэцэрлэгээр дахиад удаан холхисон бөгөөд зүүн хэрэмнээс Анагаах танхим руу олон харж байв. Өрөөндөө орж ирээд захирагчийг дуудахад тэр Ристанийн хатан хааны талаар мэддэг бүхнээ ярьж өгөв.

- Эзэн минь, та хажуугийн өрөөнд байгаа жижиг биетээс илүү ихийг мэдэж болно шүү, тэр эзэн захирагчийн хамгаалалтанд байсан, байлдааны талбарт хатан хааныг аварсан гэж ярьцгааж байсан – гээд анагаах танхимын захирагч гарлаа.

Мерриг Фарамир дуудан ирүүлж, бараг өдөржин хуучлав. Фарамир олон зүйл мэдэж авснаас гадна, ярьснаас нь ургуулан бодсоор Ристанийн эзэн захирагчийн бүл дүүгийн талаар ихийг ойлголоо. Тунгалагхан үдэш Фарамир, Мерри хоёр цэцэрлэгээр зугаалсан боловч Эовин танхимаас гарч ирсэнгүй.

Гэвч маргааш өглөө нь цасан цагаан өмсгөлтэй Эовин хэрмийн дээр зогсч байгааг хараад Фарамир дуудахад тэр бууж ирэв. Тэр хоёр өвсөн дээгүүр алхалж, саглагар модны ёроолд сууж, заримдаа өөр өөрийн бодолдоо автан дуугүй явж, заримдаа аяархан ярилцаж байв. Маргааш нь ч, нөгөөдөр нь ч ингэж өнгөрлөө. Анагаах танхимын захирагч тэр хоёрыг цонхоор хараад их баярлаж байв. Эдгэрэх явц найдвартай бөгөөд хурдан болж байгаа юм чинь анагаагч баярлалгүй яах билээ.

Тав дахь өдөр нь хатан хаан Эовин бас л Фарамиртай хотын хэрмэн дээр зогсоод алсыг хараачилж байв. Урьдын адил ямар ч мэдээ ирээгүй, хотынхны царай урвагар байлаа. Цаг агаар ч өөрчлөгдөж, эрс хүйтрэн, хойноос үлээсэн салхи улам ширүүсэн уйтгарт хөндийгөөр исгэрэн ульж байв.

Тэр хоёр дулаан хувцасласан байв. Эовин цуван дээгүүрээ хормойдоо мөнгөн ододтой хар хөх өнгийн нөмрөг хөдөрчээ. Тэр нөмрөгийг Фарамир авчруулж, өөрөө Эовинд нөмөргөхдөө хатан хааны ихэмсэг гоо сайхныг сэмхэн ширтэн биширч байлаа. Энэ нөмрөгийг Фарамирын ээж Финдуиль өмсдөг байсан бөгөөд цагаас эрт хальсан ээжийнхээ хагас мартагдсан гоо сайхныг бага хүү нь зүрхэндээ хадгалсаар байлаа. Эовины гунигтай гоо сайханд энэ нөмрөг зохино гэж тэр бодсон ажээ.

Хатан хаан нөмрөг нөмөрсөн ч даарч байсан бөгөөд шуурга исгэрэн, тэртээ алсад тэнгэрийн хаяа цэлмэж байгаа хойт зүг рүү харсаар байв.

- Чи тэндээс юу олж харахыг хүсээ вэ, Эовин?

- Хар хаалга тэнд байдаг биз дээ? Тэр тэнд л очсон байх. Тэрнийг явснаас хойш долоо хонолоо шүү дээ.

- Тийм ээ, долоо хоносон. Намайг уучлаарай, энэ долоо хоног намайг урьд нь мэдэрч байгаагүй баяр баясгалан, сэтгэлийн зовлонгоор шагналаа. Чамайг харж байгаа болохоор баяр баясгалан, зовлон нь болохоор миний хувьд энэ харанхуй зуу дахин зузаарлаа. Олж авснаа алдахаас би айж байна.

- Олсон юмаа алдах гэнэ ээ? Чи юу олсон юм бэ, эзэн минь? – гэж асуугаад тэр Фарамир руу ширүүн бөгөөд өрөвдөнгүй харж:

- Энэ аймшигт өдрүүдэд чи юу олж, юу алдахаас айж байгааг чинь мэдэхгүй юм. Найз минь, энэ тухай нэг ч үг бүү хэл! Дуугүй байцгаая! Би харанхуй ангалын дээр зогсч байна, ар талаас гэрэл гарах эсэхийг би мэдэхгүй байна, эргэж харахаас айж байна. Би хувь тавилангийн шийдвэрийг хүлээж байна.

- Тийм дээ, бид бүгдээрээ тэрийг чинь хүлээж байна.

Дахиад тэр хоёр нэг ч үг хэлсэнгүй, салхи намдаж, нар бүүдгэрч, хөндий даяар нам гүм, хот ч аниргүй болов. Шувуу ч жиргэхгүй, навчис ч сэржигнэхгүй, амьсгал ч чимээгүй. Тэдний зүрх зогсч, цаг хугацаа ч зогсох шиг санагдав.

Тэр хоёрын гар санамсаргүй уулзаж, чанга атгалцахыг тэр хоёр өөрсдөө мэдсэнгүй. Тэгээд л өөрсдөө ч мэдэхгүй нэг л юмыг хүлээгээд байв. Удалгүй алсын уулсын цаанаас бүх ертөнцийг залгихад бэлэн их харанхуй давалгаалан аянга цахилгаан галбуулсаар тэнгэрт хөөрөх шиг санагдав. Газар дэлхий доргиж, Минас-Тиритийн хана хэрэм чичирхийлэв. Дараа нь газар санаа алдах шиг болоод тэдний зүрх дахин цохилж эхэллээ.

- Яг л Нуменорт болсон шиг - гэж Фарамир хэлчихээд ингэж хэлсэндээ гайхав.

- Нуменорт гэнэ ээ?

- Тийм ээ, Нуменорт. Өрнөд гүрэн мөхөж, хар давалгаа уулнаас дээш босч, цэцэгт хөндийнүүдийг живүүлэн, ертөнц дээрх бүх юмыг арчиж хаяад, үл сарних харанхуй болох үе шиг. Надад байн байн зүүдлэгддэг юм.

- Тэгэхээр чи үл сарних их харанхуй нөмөрлөө гэж бодож байна уу?

Эовин гэнэт Фарамирт наалдав.

- Үгүй ээ – гээд Фарамир түүний нүүр рүү харж:

- Зүгээр л надад тэгж санагдсан юм. Юу болсныг хараахан мэдэхгүй байна. Эрүүл ухаанаар бодоход ертөнцөд дийлдэшгүй хүчтэй хар хор нүүрлэж, сүүлчийн цаг болсныг хэлж байна. Гэвч зүрх үүнийг зөвшөөрөхгүй байна. Амьсгалахад ч хөнгөн болж байна, итгэл найдвар зүрхгэй хамт эрүүл ухааныг эсэргүүцэн сэргэж байна. Эовин, Эовин, Ристанийн Цагаан дарь эх минь, ямар ч харанхуй энэ мөчөөс эхлэн биднээс холдог!

Тэр тонгойж түүний духан дээр үнсэв.

Тэр хоёр ийнхүү Минас-Тиритийн хэрэм дээр зогсч, сэвэлзүүр салхи хар, алтан шаргал үсийг нь хийсгэн нийлүүлж байлаа. Харанхуй алга болж, нар гийн, Андуины ус мөнгөрөн гялалзаж, яагаад ч юм бүх байшинд хүмүүс юу болсныг мэдээгүй мөртөө баярлан дуулалдав.

Үдийн нар баруун тийш ташиж амжаагүй байхад аварга том бүргэд ялалтын баярт мэдээ авчрав. Тэр мэдээ бүхий л найдвараас ч эрхэм дээд байсан бөгөөд аварга бүргэд тунхаглан зарлав:

Дуулцаа, баярлацгаа, Баруун газрын хүмүүс ээ!

Дууслаа, Сауроны хаанчлал эцэс боллоо.

Дайсны хар цайз хумхийн тоос боллоо.

Дуулцаа, хөгжилдөцгөө, нийслэлийн хамгаалагчид аа!

Дуурьсах алдар чинь та нарынх,

Хар хаалга байсан газраар

Хаан чинь ялалттайгаа хамт орлоо.

Хатан болд илд нь аянганаас хуриц гялалзаж байна.

Эзэн хаан чинь эргэж ирлээ!

Эзэмшил газартаа мөдхөн очиж

Эртний хаан ширээндаа заларна.

Цайсан мод дахин цэцэглэнэ,

Цагаан цамхгийн дэргэдээс

Цаг тоолол шинээр эхэлнэ.

Дуулцаа, баярлацгаа хүмүүс ээ!

Гудамж талбай бүхэнд хүмүүс дуулалдан баярлацгааж байлаа.

Тэгээд л алтлаг өдрүүд үргэлжилж, хавар, зун хоёр нэг болон нийлж, Гондорын нуга хөндийнүүд зун шиг цэцэглэв. Каир-Андросаас элч нар давхин ирж, нийслэл хот эзэн хаанаа угтаж авахаар гоёж гоодов. Мерриг эзэн хаан дуудсан тул тэр ачаа хөсөг авч Осгилиат ороход тэнд Каир-Андрос руу явах хөлөг онгоц хүлээж байлаа. Фарамир ялалтын баярт явсангүй, бие нь сайжирмагц тэр нийслэл хотын ажил хэргийг удирдав. Хийх ажил тун ч их байлаа.

Эовиныг дүү нь ялалтын баярт урьсан боловч явсангүй, Минас-Тиритэд үлдлээ. Фарамир

үүнд бага зэрэг гайхжээ. Тэр хоёр бараг уулзалдахгүй байгаа бөгөөд эзэн захирагч өглөөнөөс үдэш болтол завгүй ажилтай, Хатан хаан Анагаах танхимын цэцэрлэгээр ганцаараа алхаж байлаа. Тэр дахиад л гунигтай, цонхийсон царайтай болж, хот даяар дуугаа хураасан ганц хүн болов. Анагаах танхимын захирагч үүнд санаа зовж, Фарамирт илтгэв.

Тэгээд Фарамир танхим орж, дахиад л хоёулаа хотын хэрмэн дээр гарлаа. Фарамир шууд асуув:

- Эовин, чи яагаад хотод үлдсэн юм бэ? Яагаад Кормаллен руу ялалтын баярт явсангүй вэ? Тэнд чамайг хүлээцгээж байгаа шүү дээ.

- Чи өөрөө таамаглахгүй байна уу?

- Хоёр шалтгаан байж болох юм. Чухам аль нь вэ гэдгийг хэлж мэдэхгүй байна.

- Чи шууд л хэл, би оньсого таах дургүй!

- За яахав хатан хаан минь, хүсч байгаа бол шууд хэлье. Нэг бол чамайг зөвхөн дүү чинь урьсан, чи Арагорныг харахыг хүсээгүй. Яагаад гэвэл Эленделийн шууд удам бөгөөд залгамжлагчийн ялалт чамд баяр хөөр авчраагүй. Нэг бол би тийшээ яваагүй, чи надад энэ хугацаанд дасч амжсан. Магадгүй аль аль нь ч байж болох юм, чи өөрөө мэдэж байгаа. Надад хэлээч, Эовин, чи надад хайртай юу, эсвэл энэ хайр чамд хэрэггүй юу?

- Намайг өөр хүн хайрлаж байсан болоосой, намайг хэн ч огтхон ч өрөвдөх хэрэггүй...

- Би энийг мэднэ ээ. Чи манай эзэн хаан Арагорны хайрыг хүссэн. Тийм ээ, тэр агуу бөгөөд хүчирхэг. Чи түүний алдар сууг хуваалцаж, энэ дэлхий дээр түүнтэй хамт мандахыг мөрөөдсөн. Чи идэр залуу дайчин шиг жанжиндаа дурласан. Түүнийг хувь заяа асар өндөрт өргөлөө, тэр хэнээс ч илүүгээр ингэх гавьяатай хүн. Гэвч тэр чамайг хайрлахын оронд ойлгож, өрөвдсөн учир чи аль алийг нь орхиод тулалдаанд амиа өргөсөн нь дээр гэж бодсон. Над руу хар л даа, Эовин!

Эовин Фарамир луу удаан ширтэв.

- Эовин, өрөвдөх гэдгийг бүү муу юм гэж бод, энэ бол өгөөмөр буянт зүрхний бэлэг! Харин миний чамд өгч байгаа бэлэг бол түүнтэй төрөл ч гэсэн өөр. Чи бол баатар дайчин Хатан хаан, чиний алдар бөхөхгүй. Гэвч чи ертөнц дээрх бүхнээс сайхан, хайрт минь, чиний гоо үзэсгэлэнг эльфийн хэлээр ч илэрхийлэх боломжгүй. Би чамд хайртай. Эхэндээ чиний уй гуниг миний сэтгэлийг хөндсөн, харин одоо би чамайг хамгийн их хөгжилтэй, бүр аалигүй байсан ч, Гондорын гуниггүй хатан хаан байсан ч хайрлана гэдгээ мэдэж байна. Чи намайг хайрлахгүй байна уу, Эовин?

Эовины зүрх цочин булгилж, өвөл гэв гэнэт зунаар солигдсон мэт бүх юм өөрөөр үзэгдэв.

- Байж болмооргүй юм! Би жаргах нарны цайз - Минас-Анорын хэрэм дээр зогсч байна, амьсгал давчдуулсан харанхуй үүрд алга болсон, нар мөнхөд гэрэлтэж байна! Би цочиж сэрэх

шиг боллоо. Одоо би морьт дайчидтайгаа тулааны урлагаар өрсөлдөхгүй, үхлийн тулалдааны баяр баясгалангийн тухай дуу дуулахгүй юм шиг байна. Тэгснээс анагаагч болж, амьд бүхнийг хайрлан хамгаалж, ургаж цэцэглэж байгаа бүхнийг асарч тордох нь дээр гэж ойлголоо – гээд тэр дахин Фарамир руу харж:

- Би бас хааны хатан болмооргүй байна.

Фарамир хөгжилтэй инээв.

- Энэ чинь их сайн хэрэг байна, яагаад гэвэл би хаан биш. Гэвч би Ристанийн Цагаан дарь эх зөвшөөрвөл түүнийг гэргийгээ болгоно оо. Аз жаргалтай сайхан өдрүүд ирнэ, бид их мөрний цаад эрэгт, Италийн цэцэрлэгт амьдарна. Миний хатан хааныг цэнгүүлсэн ямар сайхан цэцэрлэг болно гээч!

- Тэгэхлээр Гондорын их ван чамаас болоод би Ристаниасаа салах гэж үү? Чиний ихэмсэг гондорчууд чинь: “Манай эзэн захирагчийн байж байгаа царайг хараач. Ристанийн морьт дайчинг гэргий болгоод авчихлаа! Нуменорын удмаас өөр хүүхэн олдоогүй юм байх даа?” – гэцгээнэ биз.

- Юу дуртайгаа ярьж байг л дээ – гээд Фарамир Эовиныг тэвэрч, бүхний нүдэн дээр үнсэв. Хэн ч харсан яадаг юм бэ? Хэдэн ч хүн харсан яадаг юм бэ?

Тэр хоёрыг олон хүн харжээ. Нарны туяа гийсэн хоёр хэрэмнээс бууж, гар гараасаа хөтлөлцөн Анагаах танхим руу орохыг ч олон хүн харжээ.

Фарамир Анагаах танхимын захирагчид:

- Ристанийн хатан хаан Эовин бүрэн эдгэрлээ – гэж хэлэв.

- Сайн байна, би Хатан хааныг Анагаах танхимаас тантай хамт гаргаж байна. Түүнд дахиад ямар ч эмгэг бүү хүрэх болтугай! Түүний дүү, Ристанийн эзэн захирагчийг ирэх хүртэл хатан хааныг Гондорын эзэн захирагчид даатгаж байна.

Гэвч Эовин хэлэв:

- Одоо би гарахыг хүсэхгүй байна, эндээ үлдье. Танхимд байх надад сайхан байна, би өөртөө хийх ажил олно.

Тэгээд эзэн захирагч Эомерийг ирэх хүртэл Анагаах танхимд үлдлээ.

Хаан ширээнд залах ёслолд бэлтгэж, Гондорын газар бүрээс Минас-Тирит рүү хүмүүс цувлаа. Эзэн хаан эргэж ирсэн тухай мэдээ Мин-Риммоноос Пиннат-Гелин хүртэл, хамгийн алс тэнгисийн эрэг хүртэл тарсан учир чадах бүхэн нийслэл рүү яарч байлаа. Дүрвэж явсан хүүхэд эмэгтэйчүүд тэвэр тэвэр цэцэгтэй гэртээ эргэн ирж, Дол-Амротаас шилдэг арфистууд, хийлчид, бишгүүрчид, мөнгөн бүрээчид, Лебенниний дуучид ирцгээв.

Үдэш болоход ногоон талд цэргийн асар майхнууд ярайж байгаа нь хэрэм дээрээс харагдаж,

хот шөнөжин гэрэлтэй байлаа. Хэн ч унтсангүй, өглөө болохыг хүлээн ажлаа амжуулж байв. Цэлмэг тунгалаг өглөөний нар дорнод уулсын дээгүүр мандан гарч ирэхэд бүх хонх жингэнэж, бүх туг далбаа намирлаа. Цагаан цамхгийн дээр эзэн захирагчдын мөнгөлөг цагаан туг мандав.

Өрнөдийн цэрэг нийслэлд ойртон ирэхэд хүмүүс хэрэм дээрээс харж байлаа. Нарны туяанд зэр зэвсэг, хуяг дуулга нь гялалзан, эгнээ эгнээгээрээ урагшилсаар Их хаалганы өмнө, хэрэмнээс долоон зуун фут зайд ирээд зогслоо. Хаалга байгаагагүй бөгөөд оронд нь гинж татаж, мөнгөлөг-хар өмсгөлтэй харуулууд илдээ сугалан зогсчээ. Тэдний өмнө эзэн захирагч Фарамир, түлхүүр хадгалагч Турин, бусад захирагчид, Ристанийн хатан хаан Эовин, жанжин Эльфхельм болон Мустангримын баатар вангуудтай зогсч байв. Эвдэрсэн хаалганы хоёр талаар хотын иргэд гоёлын хувцастайгаа тэвэр дүүрэн цэцэгтэй жагсчээ.

Минас-Тиритийн хэрмийн өмнө том талбай засч, Гондор, Мустангримын дайчид, Минас-Тиритийн болон ойролцоох хот суурингийн иргэд тойрон хамгаалж байв. Бүгд чимээгүй болж, цэргийн жагсаалаас мөнгөлөг саарал хөө хуягтай дунаданчууд тасран гарч ирэхэд манлайд нь эзэн хаан Арагорн явж байлаа. Тэрбээр хар хөө хуягтай, мөнгөн бүстэй, мөрөндөө цагаан нөмрөгтэй байх бөгөөд хүзүүндээ товчилсон нөмрөгний ногоолин товч холоос гялалзан харагдаж байв. Дуулга өмсөөгүй, духан дээр нь одтой мөнгөн титэм гялалзаж харагдана. Түүнтэй хамт Ристанийн Эомер, Имраиль ван, цав цагаан өмсгөлт Гэндалф, бас дөрвөн жижиг биет зэрэгцэн явна.

- Үгүй ээ, үеэл минь, эд нар чинь хүүхэд биш! - хэмээн Иорета Имлот-Мелуигээс ирсэн садангийн авгайдаа хэлээд:

- Эд нар чинь их хол байдаг жижиг биетүүдийн орноос ирсэн юм. Тэндээ манай вангуудаас дутахгүй баатар вангууд гэнэ лээ. Би мэдэлгүй яахав, нэгийг нь танхимдаа эмчилж байсан юм. Нуруу намхан ч гэсэн хэнээс дутахгүй баатар зоригтой хүмүүс. Ийм жижигхэн амьтан туслахтайгаа хоёулхнаа харанхуй хязгаарт очоод, Хар эзэн рүү довтолж, хар шидийн цайзыг нь үнс болтол шатаасан гээд л бодчих. Итгэвэл итгэ, байвал бай. Худлаа хэлээд яахав, өөрөө үзсэн биш, хотоор нэг тэгэж ярьцгааж байна. Нөгөөх чинь манай эзэн хаант Эльфийн Берилл Элессартай зэрэгцээд явж байгаа мөн дөө. Энэ хоёр үй зайгүй найз юм гэнэ лээ. Манай эзэн хаан Элессар бол гайхамшигийн гайхамшиг, жаахан ширүүн л хүн байгаа юм, гэхдээ сэтгэл нь алт аа алт, гол нь ямар ч өвчнийг гараа хүргээд л анагаачихдаг юм. Бодоод үз! Энэ ч надаас болсон юм л даа. Би “Эзэн хааны гарт эмчлэх хүч байгаа” гээд хэлчихсэн юм. Тэгээд л энэнийг дуудсан юм байхгүй юу. Митрандир надад яг ингэж хэлсэн юм, сонсч бай: “Чиний үг ч алт юм аа Иорета, энэ үгийг чинь хүмүүс их удаан санах болно!” – гэсэн юм даа, тэгээд...

Гэвч Иорета тосгоны хамаатан авгайдаа дараа нь юу болсныг ярьж амжсангүй, бүрэнүүд нэгэн зэрэг цуурайлахад талбай нам гүм болов. Хаалганаас Фарамир, Турин хоёр урагш гарч ирэхэд хойноос нь ёслолын хуяг дуулгатай дөрвөн хамгаалагч лебетрон хэмээх мөнгөөр тоногдсон хар модон авдар дамжлан дагаж явлаа.

Талбайн төвд очоод Фарамир өвдөг нугалан мэхийж:

- Ингээд Гондорын сүүлчийн эзэн захирагч бүрэн эрхээ шилжүүлж байна! – гээд Арагорнд

цагаан очир барихад Арагорн түүнийг хүлээж авангуутаа эргүүлэн барьж хэлэв:

- Чиний алба дуусаагүй, бүрэн эрхийг чинь миний эзэнт гүрэн оршиж байгаа цагт чамд болон үр удамд чинь дахин олгож байна. Албан үүргээ биелүүлэгтүн!

Тэгэхэд нь Фарамир эгцлэн зогсоод цангинасан чанга дуугаар тунхаглан зарлав:

- Ардууд, цэргүүд ээ, Гондорын эзэн захирагчийн үгийг анхааран сонсогтун! Та нарын өмнө бараг мянган жил эзэнгүй байсан их хааны ширээг хууль ёсоор залгамжлагч ирээд байна. Энэ бол Арнорын дунаданчуудын удирдагч, өрнөдийн цэргийн жанжин, умардын титэмтэн, шинээр давтсан Андриль илдийг баригч, агуу тулалдаанд ялагч, анагаашгүй өвчнийг анагаагч, Араторны хүү Арагорн. Энэ бол Эльфийн Берилл, Нуменорын Элендилийн хүү Исилдурын хүү их хаан Валандилын хүү Арнорын шууд удмын эзэн хаан Элессар мөн. Энэ хүн манай хотод орж, манай улс орны эзэн хаан болох ёстой юу? Та бүхэн зөвшөөрч байна уу?

“Зөвшөөрч байна!” – хэмээн асар олны их дуу алс холд хүртэл аянга мэт нүргэлэв. Иорета дахиад садангийн авгайдаа:

- Хараа биз үеэл минь, энэ бол зүгээр нэг төрийн ёслол биш, ингэхгүй бол болохгүй. Ер нь тэр хотод аль хэдийн орсон юм шүү дээ. Би чамд түрүүн хэлсэн дээ. Тэр манай танхимд орж ирээд надад...

Гэвч Фарамир ярьж эхэлсэн тул тэр үгээ дуусгаж амжсангүй:

- Гондорын ард түмэн минь ээ, домогт өгүүлснээр, эртнээс нааш манай эзэн хааны титмийг эцэг нь амьсгал хураахын өмнө хүүдээ өмсгөдөг, хэрэв ийм тохиолдол болохгүй бол хаан ширээ залгамжлагч өөрөө ганцаараа Бунханд орж, талийгаачийн гараас титмийг авч өмсдөг уламжлалтай. Өнөөдөр бид энэ уламжлалаас татгалзахаас өөр аргагүй болсны учир би эзэн захирагчийн эрхийн дагуу манай өвөг дээдсийг захирч байсан сүүлчийн их хаан Эарнурын титмийг Рат-Диненээс авчруулсан юм.

Хамгаалагчид түүнд дөхөж очиход Фарамир авдрыг нээж, эртний их хаадын титмийг хоёр гардан өргөж харуулав. Титэм Цагаан өргөөний хамгаалагчдын дуулгатай адил боловч, хар биш, тод цагаан өнгөтэй, цахлайн жигүүртэй төстэй сувд-мөнгөн өнгөт эмжээртэй ажээ. Нуменорчууд тэнгисийн цаанаас ирсэн гэдэг билээ. Титэм дээр долоон очирт эрдэнэ, оройд нь хамгийн том очирт эрдэнэ гялалзана.

Арагорн титмийг хүлээн авч толгой дээрээ өргөөд:

- Эт Эарелло Эндоренна угулиен. Синоме маруван ар Хильдиньяр тенн Амбар-метта! – хэмээн бүгдэд дуулдахуйц өгүүлэв. Элендил салхиар жигүүрлэн тэнгисээр хөвж ирснийхээ дараа ингэж хэлсэн бөгөөд “Агуу их Тэнгис манай удмыг Дундад газарт эргүүлж авчирлаа. Миний үр удам энэ газарт үеийн үед орших болно” гэсэн ажгуу. Гэтэл Арагорн титмийг өмссөнгүй, Фарамирт буцааж өгөөд:

- Миний эртний өвийг надад буцааж авчралцсан баатруудын гавьяа зүтгэлийг хүндэтгэе. Энэ

титмийг надад Бөгж хадгалагч өргөн барьж, хэрэв зөвшөөрвөл Митрандир надад өмсгөг. Яагаад гэвэл бүх зүйл түүний санаагаар бүтсэн юм. Энэ ялалт бол түүний ялалт – гэлээ.

Фродо урагш гарч ирээд Фарамираас титмийг авч Гэндальфт өгөв. Арагорн өвдөг сөгдөхөд Гэндальф түүнд титмийг өмсгөөд:

- Их хаадын эрин эхэлж байна, ертөнцийг Валарууд захирч байгаа цагт их хаадын гүрэн мандан бадрах болтугай! – гэж ерөөв.

Арагорн эгцлэн зогсоход бүгд түүнийг анх удаа харж байгаа юм шиг мэл гайхав. Тэрбээр Тэнгисээр хөвж ирсэн эртний нуменорын хаан шиг сүрлэг өндөр болж, ид дунд насандаа яваа мөртөө тоолшгүй олон он жилийг туулж ирсэн мэт, өргөн магнай нь мэргэн ухаанаар гийж, анагаагч гар нь агуу хүчирхэг харагдлаа.

Фарамир:

- Энэ байна, эзэн хаан минь! – хэмээн дуу алдав.

Бүх бүрээ нүд ирмэх зуурт хүнгэнэн цуурайлж, их хаан Элессар хаалганы гинжинд дөхөж очиход түлхүүр хадгалагч Турин гинжийг тайлж, эзэн хаан хаалгаар орж, олон хөгжмийн аялгуу, олон хоолойн дуун доор цэцэг дэвссэн гудамжаар алхсаар их өргөөнд хүрч дотогш ороход орой дээр нь долоон од, цагаан модтой туг мандав. Ийнхүү үй олон дуунд дуулагдсан Элессар хааны эрин эхэлвэй.

Хот ч урьдахаасаа гоё сайхан болов. Домогт өгүүлснээр, эхлээд энд тэндгүй модод суулгаж, усан оргилуурууд цацран, мифрил хаалгыг шинээр барьж, гудамжуудад цагаан гантиг хавтан дэвсэж, гномууд хотыг гоёж чимэн, ойн эльфүүд ирж сонирхдог, хуучирч муудсан байшингуудыг сэргээн барьж, хаа сайгүй хүүхдүүдийн баясгалант дуу цуурайтдаг болжээ. Гуравдагч эрин дуусч, шинэ эрин өмнөх үеийнхээ гэгээн дурсамжуудыг авч үлджээ.

Хаан ширээндээ заларснаас хойшхи эхний хэд хоногт Арагорн хойшлуулшгүй чухал ажлуудаа шийдаж байв. Газар газраас ирсэн элч нарыг хүлээн авч, бууж өгсөн вастакуудад өршөөл үзүүлж, бүгдийг суллан, хордримчүүдтэй найрамдлын гэрээ байгуулж, Мордороос чөлөөлөгдсөн боолчуудад Нурнен хавийн газрыг өгчээ. Олон олон дайчдад шагнал, магтаал хүртээж, хамгийн сүүлд их хааны өмнө Берегонд гол хэрмийн хамгаалалтын захирагчийн хамт зогсов.

- Берегонд, чи Бунхны шатыг цусаар будсан, энэ бол маш хүнд гэмт хэрэг гэдгийг чи мэдэж байгаа. Түүнээс гадна чи харуулын байрыг эзэн захирагчийн болон харуулын даргын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн орхисон. Эртнээс нааш ийм хэрэг үйлдсэн этгээдийг цаазаар хороож ирсэн. Миний зарлигийг сонсогтун. Чи тулалдаанд гавьяа байгуулсан, өөрийн жанжин Фарамирын амийг аврахын тулд хууль дүрэм зөрчсөн тул ялыг чинь хэлтрүүлж байна. Гэвч гол хэрмийн хамгаалалтаас чамайг хөөх ёстой. Минас-Тиритээс ч хөөх ёстой – гэж хаан өгүүлэхэд Берегондын царай хувхай цайж, зүрх нь агших шиг болоод толгой гудайн зогсов. Тэгтэл их хаан:

- За ингэж шийдье! Чамайг Италийн эзэн захирагч Фарамирын хамгаалалтын захирагчаар томиллоо. Эмин-Арнед амар тайван амьдарч, муу үхлээс аврахын төлөө амиа хайрлалгүй албаа орхисон тэр эзэндээ зүтгэ.

Берегонд их хааны хичнээн шударга бөгөөд өршөөлтэйг бишрэн, өвдөг сөгдөж, гарыг нь үнсээд, санаа амарч баяр хөөртэй гарлаа. Хаантан Фарамирт Италийг үүрд эзэмшүүлэхээр өгсөн ба дээр нь нийслэлээс холгүй оршдог Эмин-Арнены уулсыг өгчээ.

- Моргулийн хөндий дэх Минас-Италийг үндсээр нь устгана. Хэзээ нэг цагт тэр хөндий цэвэрших л болно, гэвч тэр болтол тэнд амьдарч болохгүй – гэж Арагорн хэлжээ.

Их хаанд Ристанийн эзэн захирагч Эомер бараалхахад тэр хоёр тэврэлдэн уулзав. Арагорн хэлсэн нь:

- Би чамайг магтаал, бэлэг хоёроор доромжлохгүй. Чи бид хоёр бол ах дүү хоёр. Сайн цагийн эхэнд умард газраас Эорл давхин ирж манай холбоог байгуулсан, тэр цагаас хойш та нар ч, бид ч холбоотныхоо тангаргаас няцаагүй, хойшид ч үгүй. Одоо суут эзэн захирагч Теоден манай Бунханд нойрсч байгааг чи мэднэ, хэрэв та нар хүсвэл тэр Гондорын эзэн захирагчдын дунд нойрсч л байг. Та нар хүсэлт тавибал бид түүний шарилыг Мустангримд, өвөг дээдсийнх нь шарилын дэргэд хүргэж өгнө.

Эомер:

- Талын ногоон өвсөн дунд чи миний өмнө зогссон тэр өдрөөс хойш би чамд үүрд хайртай болсон. Одоо би цэргээ Ристанид татаж, энх тайван амьдралаа тохинуулах хэрэгтэй байна. Боломж гармагц бид тулалдаанд унасан эзэн захирагчийн шарилыг авахаар ирнэ.

Эовин Фарамирт хэлэв:

- Би эх орондоо эргэж очих хэрэгтэй байна. Эх орноо дахин нэг харж, дүүгийнхээ нөр их ажилд туслах хэрэгтэй. Олон жил би эцгээ гэж бодож явсан тэр хүн Эдораст мөнхийн амгалангийн өргөөндээ заларсны дараа би чам дээр ирнэ.

Баяр ёслолын өдрүүд ийнхүү өнгөрч, тавдугаар сарын найманд Ристанийн морьт дайчид эх орондоо буцахаар умард замд гарахад Элрондын хөвгүүд хамт явлаа. Хотын хэрэмнээс Пеленнор хүртэл замын хоёр талаар хүмүүс цугларч, холбоотнуудтайгаа салах ёс гүйцэтгэв. Дараа нь Гондорын алс нутгийн хүмүүс гэр гэртээ очиж ялалтаа тэмдэглэхээр хөдөллөө. Хотод сэргээн босголтын их ажил өрнөлөө.

Хоббитууд, Леголас, Гимли нар Арагорны хүсэлтээр Минас-Тиритэд түр үлджээ.

- Ертөнц дээрх бүх юм цаг нь ирэхээр төгсгөл болдог. Гэхдээ та нар жаахан хүлээж бай. Бид хамтдаа оролцсон зүйлийн зарим нь хараахан дуусаагүй байна. Миний аль эртнээс хүсэн хүлээж байсан тэр өдөр ойртож байна. Тэр өдөр ирэхэд найз нар минь надтай хамт байхыг би хүсч байна – гэж тэр хэлжээ. Харин ямар учиртай өдөр болох талаар нэг ч үг хэлээгүй ажээ.

Бөгж хадгалагч байсан андууд нэгэн тохилог байшинд сууж, Гэндальф ч тэднээс холдсонгүй, хамтдаа хаа дуртай газраараа зугаалж байлаа. Нэг удаа Фродо Гэндальфт хэлэв:

- Арагорны ярьсан тэр өдрийн тухай чи мэдэж байгаа биз дээ? Бидэнд энд сайхан л байна, хаашаа ч яарах юм алга. Харин өдөр хоног явсаар л байна, Бильбо намайг хүлээж байгаа, Хоббитанидаа ч очих цаг болсон шүү дээ.

- Бильбогийн тухайд бол тэр өдрийг чинь л хүлээж байгаа, чамайг яагаад очихгүй байгааг ч мэдэж байгаа. Өдөр хоног өнгөрч байгаа нь үнэн, гэхдээ одоо тавдугаар сар, зун хараахан болоогүй. Шинэ эринээс хойш олон юм өөрчлөгдсөн боловч өвс ургамал өөрийн цаг тоололтой. Та хоёр салснаас хойш өвс ургамлын тооллоор нэг жил ч болоогүй.

- Хараа биз Пин. Гэндальф урьдынх шигээ нууцлаг биш, их яриасаг болсон гэж чи хэлж байсан байх аа! Тэгэхэд жаахан ядарсан байлгүй. Харин одоо бол Гэндальф Гэндальфаараа л байна – гэж Фродо Пинд хэлэхэд Гэндальф:

- Ширээн дээр ямар хоол тавихыг идэх гэж байгаа хүмүүс бүгдээрээ л урьдчилж мэдэхийг хүсдэг. Харин хоол хийж байгаа хүн хэлэхийг хүсдэггүй. Санаанд ороогүй хоолыг нь гэнэт тавих тогоочид аятайхан байдаг юм. Энэ удаад Арагорн өөрөө ч гэсэн дохио хүлээж байгаа.

Нэг сайхан өдөр Гэндальф усанд унасан юм шиг гэнэт алга болов. Хоббитууд болон Леголас, Гимли хоёр гараа алдлан гайхахаас хэтэрсэнгүй.

Урьд шөнө нь Гэндальф Арагорныг дагуулан хэрэмнээс цааш хол явж, Миндоллуины өмнөд бэлд хүрээд, аль дивангарт мартагдсан нэг жимийг эрж олжээ. Тэр замаар нэгэн цагт зөвхөн их хаад л ганцаар уулан дээр гарч, сэтгэж, бясалгадаг байсан ажээ. Тэр хоёр эгц хясааны ирмэг даган өгссөөр мөнх цасны хормой дахь өндөр дэвсэг дээр гарав. Минас-Тиритийн арын оргил дээрээс эргэн тойрноо халиахад үүр хаяарч, хотын цамхгууд тэртээ доор өглөөний нар туссан дэрс шиг, Их мөрний хөндий ногоон цэцэрлэг шиг үзэгдэж, Изгарын уулс алтлаг мананд хучигдсан байв. Умар зүгт Мөрний хавийн уулс бүдэгхэн цайрч, хөөст Рэрос алсын одод шиг гялалзаж, Андуины мөнгөн тууз өмнө зүг, Пеларгир руу одож, цаана нь тэнгэрийн хаяанд тэнгисийн гэгээ туяарч байв.

Гэндальф:

- За чиний өнөөгийн улс чинь энэ дээ. Үүнтэй харьцуулшгүй том болно оо. Гуравдагч эрин дууссан, өөр эрин ирж байна. Түүний эхлэл ямар байхыг тодорхойлох хувь чамд тохиосон, хадгалж үлдээж болох бүхнийг хадгалаарай. Олон юмыг аварч амжсан ч олон юм оргүй алга болсон. Эльфийн гурван бөгж одоо Дундад газарт захирагдахгүй, чиний харж байгаа бүх газарт, харагдахгүй байгаа газарт ч хүмүүс суурьшина, яагаад гэвэл хүмүүсийн хаанчлалын эрин эхэлж байна. Цаг хугацааны ууган хүүхэд эльфүүд тарж, мөхөж, хөвж одно.

- Энийг би мэднэ ээ, эрхэм анд минь, гэхдээ чи миний зөвлөхөөр үлдэнэ биз дээ?

- Удахгүй, би өнгөрч одсон гуравдагч эриний төлөөлөгч. Би Сауроны гол дайсан байсан, хийх юмаа хийчихсэн. Явах цаг минь болсон. Одоо энэ газар дэлхийг чи, чиний төрлийнхөн

хариуцна.

- Гэвч би удахгүй үхнэ шүү дээ. Би ердийн л үхэлт амьтан. Хэдийгээр нуменорчуудын шууд удам урт насалдаг ч одоо эхийн хэвлийд байгаа үрс хөгшрөхөд би ч бас хөгширнө. Тэр цагт Гондорт, Минас-Тиритийг нийслэлээ болгосон бүх хүмүүст юу тохиолдох вэ? Оргилуурт ордонд байгаа мод хатсан чигээрээ байна, нэг ч нахиа алга. Сэргэн шинэдэх баталгаа надад харагдах уу?

- Цэцэглэж байгаа хязгаараас харцаа салгаад нүцгэн хадан хясаа руу хар!

Арагорн эргэж, цасан малгай доорх цахиурлаг цохио руу харав. Элгэн хадан дунд ганц мод харагдлаа. Тэр тийшээ авирч хүртэл үнэхээр цасан бүрхүүлт хадан хөрсөнд бараг гурван фут өндөр мод ургасан байлаа. Навч нь аль хэдийн дэлгэрч, уртавтар, сийлсэн мэт уран нарийн, мөнгөлөг үсэнцэр бүхий хар ногоон навчистай мод байх бөгөөд оройд нь жижигхэн цагаан цэцэг наранд гялалзах цас мэт гялтганан байв.

Арагорн:

- Йе! утувьенес! Би түүнийг оллоо! Энэ бол эртний модны удам мөн байна! Яаж энд ургасан юм бол оо? Лав долоон нас хүрсэн дэг ээ!

Гэндальф хүрч ирээд:

- Үнэхээр тийм байна. Энэ бол хамгийн эртний мод – Олон нэрт Телпероины удам Галаилионоос төрсөн гоёмсог Нимлотын суулгац байна. Харин энд яаж ирснийг нь бид мэдэх албагүй. Гэхдээ чухам энд л ариун хөрс байж, их хаадын удам тасарч, Цагаан мод хатахаас өмнө энд Нимлотын үрийг суулгасан нь илт байна. Домогт өгүүлснээр, тэр мод үр өгөх нь ховор боловч, нэгэнт өгсөн үр нь олон зуун жил амьд байдаг учир хэзээ ургахыг нь хэн ч мэддэггүй гэдэг юм. Миний үгийг санаж яваарай. Хэрэв энэ мод үр өгвөл бүх үрийг нь нэгийг ч үлдээлгүй суулгах ёстой. Тиймээ энэ үр Элендилийн үр удам умард нутагт нуугдсан шиг мянган жил энд булаастай байжээ. Гэхдээ Нимлотын удам танай удмаас хамаагүй дээр үеийнх шүү, эзэн хаан Элессар.

Арагорн модыг аяархан хөдөлгөхөд мод ер бусын хурдан газраас сугарч, бүх үндэс нь бүрэн бүтэн байлаа. Арагорн түүнийг гар дээрээ өргөн авчирч их өргөөний хашаанд суулгав. Хатсан Цагаан модыг өндөр хүндэтгэл үзүүлэн ёслол үйлдэж, малтан аваад Рат-Диненд оршуулав. Түүний буурин дээр Арагорн залуу модыг суулгахад дөнгөж зургадугаар сарын эх гэхэд багсайтал цэцэглэв.

- Баталгаа үнэн байна. Миний амьдралын хамгийн сайхан өдрүүд ойрхон байна – гэж Арагорн өгүүлээд эргэн тойронд нь харуул тавилаа.

Нар буцахын өмнөх өдөр нийслэлд Амон-Диний уулсаас элч нар давхин ирж, умар зүгээс эльфүүдийн морьт отряд Гондор руу ирлээ, одоо Пеленнорын ханын дэргэд ирээд байна гэж мэдээлэв.

Арагорн:

- За ашгүй дээ! Хотыг агуу их баярт бэлтгэ! – хэмээн зарлиг буулгав.

Үдэш болж, цэлмэг цэнхэр тэнгэрийн дорно хэсэгт одод гялалзаж, өрнө хэсэг нь жаргасан нарны туяанд улайрсан хэвээрээ, анхилам салхи сэвэлзэж байхад умардын зочид Минас-Тиритийн хаалган дээр хүрч ирлээ. Саарал нөмрөг хөдөрч, үсэндээ эрдэнийн чулуун хавчаар шигтгэсэн эльфүүдийн ёслолын цувааны тэргүүнд Элроир, Элладан хоёр мөнгөн залаа өргөж, дараа нь Всеславур, Эрестор хоёр болон Элрондын гэрийнхэн бүгдээрээ, тэгээд Кветлориэний эзэд – Галадриэль, Келеборн хоёр цагаан морь унаж явах бөгөөд цувааны сүүлд хүмүүс болоод эльфүүдийн дунд адилхан алдаршсан Элронд эртний нийслэл Арнорын очир Ануминасыг өргөн явна. Түүний дэргэд эльфийн үдшийн од хэмээн алдаршсан охин Арвен нь жороо саарал морьтой явна. Түүний титэм очир эрдэнээр туяаран, анхилам үнэрт гоо үзэсгэлэнгийнх нь энхрийхэн гэрэлд үдшийн гэгээ тодрох шиг болов.

Фродо Гэндальфт хандаж:

- Бид юугаа хүлээгээд байсныг одоо л мэдлээ. Хүлээсэн минь сайн болов. Бидний хүлээсэн тэр өдөр байтугай шөнө нь ч гайхамшигтай сайхан болох юм байна. Бидний айдас дууслаа! – гэж бишрэн бахархсандаа амьсгаа давхцуулан өгүүлэв.

Эзэн хаан зочидтойгоо мэндэлж, баяр хүргэсний дараа зочид мориноос бууж, Элронд Арагорнд очироо гардуулаад, охиныхоо гарыг Арагорны гарт атгуулахад ёслолын цуваа гудамжаар дээш өгслөө. Тэнгэр бүхэлдээ оддын гэрэлд хучигдав. Ийнхүү Арагорн, их хаан Элессар Арвен Ундомиэльтэй нар буцахын өмнөхөн хуримлаж, тэр хоёрын удаан хугацааны хагацал төгсч, хүсэл мөрөөдөл нь биелсэн бөлгөө.

Бүлэг 16

Салалт

Найр хуримын өдрүүд өнгөрч, гэр гэртээ буцах цаг болов. Фродо эзэн хаанд бараалхахад хаан хатан Арвентайгаа усан оргилуурын дэргэд, цэцэглэж буй Цагаан модны ёроолд суугаад, Арвен ятга хөгжим тоглон эртний дуу аялж байв. Фродог хараад хоёулаа баярлаж, өөдөөс нь босон мэндлэв. Арагорн:

- Чи гэр рүүгээ яарч байгаа биз дээ, Фродо. Одоо яая гэхэв, мод бүхэнд ургасан хөрс нь амттай, гэхдээ найз минь, одоо чиний эх орон чинь нийт Баруун газар тэр чигээрээ, хаана нь ч чи хүсэн хүлээсэн хүндэт зочин гэдгээ битгий мартаарай. Чиний ард түмэн агуу домгуудад дурдагдаагүй нь үнэн боловч энэ цагаас хойш ихээр алдарших болно.

- Тийм ээ, би Хоббитани руугаа их яарч байна. Гэхдээ эхлээд Уудам хөндий рүү явмаар байна. Энэ их баярт өдрүүдэд нэг л хүн дутуу байсан, тэр бол Бильбо юм. Элрондын гэр бүлийнхэнтэй хамт тэр ирээгүйд би ихэд урам хугарсан.

- Чи яагаад тэгж их урам хугардаг билээ, эрхэм хадгалагч? - гэж Арвен асуугаад:

- Чиний устгасан тэр бөгж ямар их аймшгийн хүчтэйг чи мэднэ шүү дээ. Тэр их хүчээр хийгээгүй бүхэн бүгд устаж алга болсон. Чиний авга ах тэр бөгжийг чамаас удаан хугацаагаар, маш урт хугацаагаар эзэмшиж байсан. Чиний бодлоор ч гэсэн тэр маш эртний хүн, тэрэнд аялах тэнхэл одоо байхгүй шүү дээ, чамайг л хүлээж байгаа.

- Тиймээс би тийшээ хурдан явах хэрэгтэй байна.

- Долоо хоногийн дараа хөдлөөрэй. Бид чамайг бүр Ристани хүртэл дагаж үднэ. Гурав хоногийн дараа Эомер Теодены шарилыг авахаар ирнэ. Бид хамт явна, юу хийх хэрэгтэй вэ, түүнийг хийх хэрэгтэй. Дашрамд хэлэхэд, Фарамирын чамд өгсөн амлалт хүчинтэй хэвээрээ шүү. Чи хэзээ дуртай цагтаа, ямар ч дагуулуудтайгаа Гондорын нутгаар чөлөөтэй аялах эрхтэй. Чиний гавьяаг үнэлж шагнамаар байна, гэвч гавьяанд чинь дүйцэх шагнал алга шив дээ, юу дуртайгаа аваарай, харин манай газар дээр чамайг ямагт хааны зиндаанд хүндэлнэ.

Хатан хаан Арвен хэлэв:

- Чамд тохирох шагнал бий шүү. Би чинь Элрондын охин шүү дээ. Аав маань боомт руу явахад би хамт яваагүй. Би Лучиэний адилаар үхэлт заяаг сонгосон, миний сонголт хичнээн гашуун шигээ төчнөөн баяртай. Хадгалагч чи миний байрыг эзэл. Чиний шарх тэсэхийн аргагүй өвдөх юм уу, ой дуртгалыг чинь аймшигт дурсамж дарамталж магадгүй. Өрнө зүг рүү хөв, тэнд чиний шарх эдгэрч, ядаргаа чинь бүрэн арилна. Май үүнийг ав, энэ чамд тусална, харанхуй, аймшгаас хамгаална. Элессар, Арвен хоёрыг дурсч яваарай!

Тэрбээр мөнгөн гинжтэй, оддын гялбаа шингэсэн сувдан зүүлтээ тайлж, Фродогийн хүзүүнд зүүж өгөв.

Гурав хоногийн дараа Ристанийн эзэн захирагч Эомер Мустангримын тэргүүн баатар вангуудыг тэргүүлэн Хаалган дээр ирэв. Түүнд зохих хүндэтгэл үзүүлэн угтаж авсны дараа Зоогийн өргөө Меретрондод хүндэтгэлийн зоог барилаа. Эомер хоёр хатан хааны гоо үзэсгэлэнг ухаан алдам бишэрчээ. Зоогийн дараа тэр амрахаар явсангүй, гном Гимлиг дуудаж өгөхийг хүсэв. Гимли орж ирэхэд Эомер:

- Глоины хүү Гимли, саран сүх чинь ойр байна уу?

- Байхгүй ээ эзэнтээн, гэхдээ хэрэгтэй бол аваад ирэхэд удахгүй.

- Өөрөө л мэд, бид хоёрын хооронд Алтан ойн хатан хааны талаар бага зэрэг маргаан гарсан шиг санаж байна. Маргаанаа таслаагүй шүү дээ. Тэгээд сая би хатан хааныг өөрийн нүдээр харлаа.

- Өө тийм үү эзэнтээн, тэгээд одоо юу гэмээр байна даа?

- Юу ч гэхэв дээ! Түүнийг гоо үзэсгэлэнгийн дээд гэж хүлээн зөвшөөрч чадахгүй юм байна.

- Тэгвэл би сүхэндээ явлаа.

- Гэвч эхлээд буруугаа бага зэрэг хүлээхийг зөвшөөр л дөө. Би урьд нь түүнийг харсан бол чиний хэлсэн бүхнийг зөвшөөрөөд, дээр нь бас нэмж магтах байлаа. Гэвч одоо арай өөрөөр хэлнэ. Гоо үзэсгэлэнгийн манлай бол Үдшийн од хатан хаан Арвен юм байна. Зөвшөөрөхгүй хүн байвал би өөрөө халз тулаанд дуудна. Тэгэхлээр би яах вэ, илдээ авчруулах уу?

Гимли гүнээ мэхийв:

- Үгүй эзэн минь, чи надтай халз тулалдахгүй. Чи үдшийн гоо үзэсгэлэнг сонгосон байна, миний зүрхийг өглөөний гоо үзэсгэлэн булаасан юм. Одоо миний зүрх өглөө бол биднийх биш, бид өглөөг сүүлчийн удаа харж байна гэж хэлж байна гэв.

* * *

Тэгээд салах өдөр ирж, сүрлэг их цуваа умар зүг рүү хөдлөв. Гондорын их хаан, Мустангримын эзэн захирагч хоёр Бунханд орж, эзэн захирагч Теодены шарилыг алтан дамнуурга дээр тавин гарч, анир чимээгүй хотын хаалганд авчирлаа. Дамнуургыг өндөр дугуйт тэргэн дээр тавиад Ристанийн морьт дайчид хүрээлж, Ристанийн далбааг өмнө нь бөхийлгөв. Теодений зэвсэг баригч Мерри тэргэнд сууж, эзэн захирагчийнхаа зэвсгийг өвөр дээрээ барьж явлаа.

Хадгалагч бүрт тохирсон морьд сонгосон бөгөөд Фродо, Сэм хоёр Арагорны баруун гар талд, Аянгаа унасан Гэндалф зүүн гар талд нь, Пин Гондорын гол хэрмийн хамгаалагчдын дунд, Леголас, Гимли хоёр хайртай Арод дээрээ сундалдаад, цувааны хаана нь ч хамаагүй явж байлаа.

Хатан хаан Арвен, мөн Келеборн, Галадриэль хоёр, тэдэнтэй хамт эльфийн бүх зочид болох Элронд хөвгүүдтэйгээ, Дол-Амротын вангууд, Итилийн ноёд, жанжингууд явлаа.

Ристаничуудыг Гондороос хэзээ ч ингэж их сүр бараатай үдэж байсангүй, Тэнгэлийн хүү Теоден өвөг дээдсийнхээ орд өргөө рүү агуу сүрлэг буцлаа.

Аноризэн орон руу яаралгүй тайван хүрч, Амон-Дины ой руу ороход нүдэнд ил хэн ч харагдаагүй боловч уулс нэлэнхүйдээ бөмбөрийн дуу нижигнүүлэн угтав. Арагорны зарлигаар бүрээнүүд цууриалан, зарч нар хааны зарлиг тунхаглав:

- Их хан Элессарын зарлигийг сонсогтун! Друаданы ойг Ган-бури-Ган болон түүний ард түмэнд үүрд эзэмшүүлэн өгч байна! Одооноос эхлэн тэдний зөвшөөрөлгүйгээр энэ газарт хэний ч хөл гишгэхгүй!

Хариуд нь бөмбөр дахин нижигнээд чимээгүй боллоо.

Арван зургаа дахь өдөр Эзэн зархирагч Теодены шарилыг дагасан цуваа Ристанийн тал хөндийнүүдийг туулаад Эдораст хүрлээ. Алтан өргөөг дээд зэргээр чимэглэж, хурц гэрэлтүүлсэн байв. Өргөө баригдсанаас хойш ийм том ёслол болж байгаагүй ажээ. Теодены шарилыг гурав хоногийн дараа бүрэн хуяг дуулга, зэвсэг, алт эрдэнэсийн хамт оршуулав. Булшин дээр өндөр хиргисүүр босгож, цагаан цэцгээр бүрэв. Ийнхүү оршуулгын замын зүүн талд найман хиргисүүр бослоо.

Эзэн захирагчийн торгон цэргүүд хиргисүүрийг тойрон Тэнгэлийн хүү Теодений тухай дууг дуулав. Уянгалаг урт дуунд түүний байгуулсан гавьяаг тоочин шүлэглэсний дараа:

Харанхуй дундаас сугаран гэгээн гэрлийн өөдөөс

Хурц илдний ир, хурдан хөлгийн аагаар довтолж,

Харь дайсны цэргийг хиар цохиж явахдаа,

Хайр, итгэлээр жигүүрлэж, хайр, итгэлтэйгээ унахдаа,

Үхэл, аймшигийг ялж, хувь тавилангаас өндөрт мандан

Үйлт амьдралаа алдаж, үүрдийн алдрыг олвой.

Мерри цагаан цэцэгсээр бүрхсэн хиргисүүрийн ёроолд уйлан зогссоор дуу жаргахад:

- Эзэн захирагч Теоден, ээ Эзэнтэн минь! Яасан богино хугацаанд эцгийн минь оронд эцэг болов доо, чи! Үүрд баяртай! – хэмээн халаглав.

Оршуулгын дараа бүгд алтан өргөөнд цугларч, их гашуудлыг тайлах найр эхлэв. Эзэн захирагч Теоден энэ ертөнцийн насандаа нэр төртэй амьдарч, эцэг өвгөдийнхөө нэрийг гутаалгүй баатрын ёсоор хальсан учир их найр хийх ёстой ажээ. Уламжлал ёсоор, Мустангримын бүх хаадын дурсгалыг хүндэтгэх мөч болж, нар мэт алтлаг, цас мэт цагаан хатан хаан Эовин эзэн захирагч Эомерт аварга хул дүүрэн дарс барилаа. Тэгмэгц алтан өргөөний захирагч, домгийн багш хоёр босч, Мустангримын өмнөх хаадын нэрийг дэс дараалан дуудав. Улсыг үндэслэгч Эорл, өргөө баригч Брего, Алдор, Фреа, Фреавин, Голдвин, Деор, Грам, Хельм, дараа нь эзэн

захирагчид: Фреалаф, Леофа, Вальда, Фолька, Фольквин, Фэнгэл, Тэнгэл, Теоден. Дуудаж дуусмагц Эомер хултайгаа хөнтрөх хооронд дарс аягалагчид бүх хулыг дүүргэхэд бүгдээрээ босч:

- Мустангримын эзэн захирагч Эомер эрүүл энх амьдрах болтугай! – хэмээн нэгэн дуугаар ерөөв. Дараа нь Эомер босч:

- Бидний энэ найр бол гашуудал тайлах найр. Бид эзэн захирагч Теоденг эцсийн замд нь үдэж байна, гэвч энэ найр баярт мэдээгээр гийх болтугай. Энэ мэдээг сонсоод бурхан болооч эзэн захирагч маань хамгийн ихээр баярлах байсан юм. Яагаад гэвэл тэр миний эгч Эовинг төрсөн охин шигээ хайрладаг байсан юм. Энэ өргөөнд урьд нь морилж байгаагүй, алс нутгаас ирсэн зочид сонсогтун! Гондорын эзэн захирагч, Италийн эзэн Фарамир Ристанийн хатан хаан Эовиныг гэргийгээ болгоё гэж гуйлаа. Хатан хаан зөвшөөрсөн. Ингээд энэ хоёрын сүй тавьсныг зарлаж байна, бүгдээрээ гэрч болоорой.

Фарамир, Эовин хоёр гараасаа хөтлөлцөн урагш гарч ирэхэд тэдний аз жаргалын төлөө хултай дарсаа хоосолцгоов.

- За ингээд Ристани, Гондорын холбоо улам бат боллоо, би үүнд хамгийн их баяртай байна – гэж Эомер хэлэв.

- Чи ч үнэхээр өгөөмөр юм аа, Гондорт хамгийн үнэтэй юм аа өгчихөөр танай улсад өөр юу үлдэх юм бэ! – гэж Арагорн дуугарав.

Эовин Арагорны нүд рүү харж:

- Надад аз жаргал ерөөгөөрэй, эзэн хаан минь, эмнэн анагаагч минь! – гэхэд Арагорн:

- Би чамайг анх харсан цагаасаа л чамд аз жаргал ерөөсөн. Одоо чи аз жаргалтайгаа учирлаа, энэ бол миний зүрхэнд их баяр болно – гэв.

Найр жаргаж, Эомерын зочид замдаа гарахад бэлтгэв. Арагорн баатар вангуудаа дагуулан хөдөлж, Лориэн, Уудам хөндийн эльфүүд ч замдаа гарч, Фарамир, Имраиль хоёр түр үлдэв. Арвен ч ах дүү нартайгаа салах ёс хийгээд үлдлээ. Тэр эцэгтэйгээ хэрхэн салах ёс хийснийг хэн ч харсангүй. Тэр хоёр уулан дээр гарч их л удаан ярилцсан бөгөөд үүрд хагацаж байгаа болохоор тэр хоёрын салах ёс их л гашуун байсан биз ээ.

Замд гарахын өмнөхөн Эовин, Эомер хоёр Мерри рүү хүрч ирээд:-

- Замдаа сайн яваарай, Хоббитанийн Мериадок, Мустангримын дарс аягалагч минь! Удахгүй манайд ирээрэй, бид их баярлана шүү! – гэв.

Эомер:

- Эртний заншлаа бодвол Мундбургийн тулалдаанд байгуулсан гавьяаны чинь төлөө чамайг шагнах юм бол чиний морьд байрнаасаа хөдөлж чадахааргүй болтол ачааг чинь хүндрүүлмээр байна. Даан ч чи тэртэй тэргүй өөрийнх чинь болсон хуяг дуулга, зэвсэгнээсээ

өөр юм авахгүй гэсэн. За яахав, чинийхээр болог, гэхдээ дүү маань ядаж морьт дайчин Дернхельм болон хэзээ ч мартагдашгүй тэр газарт цуурайлсан Ристанийн дайчдын бүрэн дууны дурсгал болгож үүнийг ав гэж хүсч байна.

Эовин Меррид ногоон оосортой эртний мөнгөн бүрээ өгөв. Бүрээ жижигхэн боловч их уран сийлбэртэй ажээ. Давхиж байгаа морьтнуудын дүрс, нууцлаг рун бичээс байна.

- Энэ бол манай гэр бүлийн нандин эрдэнэ. Скатыг дээрэмдсэн гномуудын ажил. Нэг тийм нэртэй луу байсан юм. Тэр лууг алаад манайхан, гномуудтай олзоо булаалдаж муудалцсан юм гэнэлээ. Энэ бүрээг Эорл умардаас авчирсан. Энэ бүрээ дайснуудын зүрхийг чичрүүлж, анд нөхдийн зоригийг бадраадаг юм. Анд нөхөд хаана ч байсан дууг нь сонсоно.

Мерри бэлгийг аваад Эовины гарыг үнсэв. Гурвуул тэврэлдэж, дахин уулзахын ерөөл тавилаа. Бүгд бэлэн болж, салалтын хул хоослоод, сайны ерөөл тавьцгаав. Зочид Хельмагийн хавцалд очиж, тэнд хоёр хоног амарлаа. Леголас Гимлид амласандаа хүрч, түүнтэй хамт Гялалздаг агуйнуудаар оров. Буцаж ирээд эльф юу ч ярьсангүй. Гимли ярина биз, тэрэнд үг олдоно гэв.

- Үгээр үзэлцэхэд гном хэзээ ч эльфийг ялж байгаагүй, энэ анхных нь. Гэхдээ Фангорнд очоод тэнцэнэ ээ! – гэж тэр амлав.

Хавцлын амнаас Изенгард руу ороод тэд онтууд ямар их ажил хийснийг үзлээ. Бүх ханыг нураан зөөгөөд, Изенгардын дотор жимсний өтгөн цэцэрлэг суулгаж, дундуур нь түргэн урсгалт гол урсган, гол дунд нь нуур тогтоожээ. Нуурын мандалд Ортханкийн цамхаг автагдашгүй хар чулуун дүрээ тольдож байв.

Аянчид хуучин хаалга байсан газарт жаахан сууж амрав. Тэнд харуул мэт хоёр өндөр мод сүглийж, тэндээс цааш Ортханк хүртэл ногоон зурвас үргэлжилжээ. Тэд ийм богино хугацаанд ямар их ажил хийгээ вэ хэмээн гайхаж, ойр хавьд нэг ч амьд амьтан байхгүй байв. Гэвч “Кгум-кгум, кхум-кхум!” – гэсэн дуу сонсдож, ногоон зурвас дээр Модон, Хурдан хоёр гарч ирэв.

- Ортханкийн цэцэрлэгийн зочдод мэнд хүргэе! Та нарыг ирлээ гэж надад хэлсэн юм. Би хөндийд ажиллаж байгаа, ажил маш их байна. Та нар ч гэсэн зүгээр суугаагүй, их сайн ажилласан, бүр дэндүү сайн ажилласан гэж би дуулсаан.

Тэгээд Модон тэднийг магтан, болсон бүх үйл явдлыг тоочив. Тэр бүгдийг мэдэж байжээ. Дараа нь дуугүй болоод Гэндальф руу удаан ширтэв..

- Чамайг би шидтэнүүдийн шидтэн гэж хэлээгүй юу. Чи гайхамшигтай их хөдөлмөрлөж, эцсийн эцэст Дайсныг дийллээ. Одоо хаашаа явж байна? Энд ямар хэргээр ирэв?

- Чамайг юу хийж байгааг харах гэж ирсэн юм, анд минь. Бас та нарт баярласнаа хэлэх гэсэн юм. Та нар байгаагүй бол бид ялахгүй байсан.

- Кгум, тэр ч үнэн байх шүү, онтууд нэр нүүрээ шавартай хутгаагүй.

- Шинэ амьдрал эхэлж байна. Одоо хүмүүсийн хаант улс чамаас ч урт насалж магадгүй, Фангорн анд минь. Харин чи одоо надад хэлээд аль. Саруман юу болж байна? Ортханкаас тэр уйдаагүй л байна уу? Тэр чиний хийж байгаа ажлыг цонхоор харж байх нь сайхан байгаа гэж үү?

Модон Гэндальф руу тун ч зальжин харах шиг Меррид санагдав.

- Аа! Чамайг энэ тухай асуух байх гэж би яг бодож байсан юм. Тэр Ортханкаас уйдаагүй байна уу гэж үү? Уйдахаар барах уу даа, Ортханк байтугай миний дуу хоолойноос залхаж гүйцсэн. Кгу-умм! Би ч сайхан зөвлөгөө өгч байсан даа, та нарынхаар бол арай л урт байх.

- Тэр яаж тэсдэг байна аа? Чи өөрөө Ортханк руу орсон юм уу?

- Би юу? Кгу-ум, би яалаа гэж тийшээ орох билээ. Тэр л өөрөө цонхон дээрээсээ мэдээ сонсдог байсан юм. Даанч сонссон мэдээ нь таалагдахгүй л дээ. Тэр хоёр чихээ дэлдийлгээд л чагнадаг байсан юм. Би ч бүгдийг сонсох гэж чармайлгүй яахав. Дээрээс нь бас тэрэнд дуулгахад гэмгүй зөндөө юм нэмчихдэг юм. Тэр арай л ханаараа мөлхөөгүй. Яаруу гэдэг нь. Тэрнээсээ болоод л үхчихсэн.

- Би ажиглаад л байна шүү, Фангорн анд минь. Чи хэнэг ч үгүй царайлаад л өнгөрсөн цаг дээр: “Сонсдог байсан, мөлхөөгүй, үхчихсэн” гээд л. Энэ чинь юу гэсэн үг вэ? Тэр үхчихээ юу?

- За даа, одоохондоо үхээгүй гэмээр юм уу даа. Гэхдээ тэр байхгүй. Алга болоод долоо хонож байна. Би тэрнийг явуулчихсан. Тэрнээс ч бага юм үлдсэн дээ. Сүүдэр л гэсэн үг. Чи надад тэрнийг манаж байна гэж амласан шүү гэж битгий хэлээрэй Гэндальф. Амлах нь ч би амласаан. Гэвч тэрнээс хойш олон юм болсон. Тэрнийг би элдвийн юм хийчих вий гэсэндээ хангалттай хорьсон. Чи намайг сайн мэднэ, би аливаа амьтанг хорьж байх дургүй. Шаардлагагүй бол хорих хэрэггүй. Хатгууртаа хоргүй бол могой мөлхөж л байг!

- Чиний зөв байх аа. Гэхдээ энэ могойны хор дуусаагүй байх вий гэж л айж байна. Тэрний дуу хоолой хортой. Чи хичнээн мэргэн ухаантай ч гэсэн тэрний ятгалгад орсон байна. Тэр чамд яаж долигнохоо мэднэ. За за, тэр чөтгөр рүүгээ тонилоо биз. Харин Ортханк ямар ч байсан хааны хөрөнгө шүү. Тэрэнд одоохондоо хэрэг болохгүй байлгүй.

- Энийг бид мэднэ. Онтууд эндээ эзэн сууж л байг. Харин Ортханкийг л харж байх хэрэгтэй. Ийшээ хэн ч ороогүй биз дээ?

- Цоожтой шүү дээ. Би Саруманд цамхгийг цоожлоод түлхүүрийг нь надад өг гэж тушаасан юм. Түлхүүр Хурданд байгаа.

Хурдан салхинд бөхийж байгаа мод шиг тонгойж, Арагорнд ган оосортой хоёр том хар түлхүүр өгөв.

- Дахиад баярлалаа. Баяртай. Ой чинь нам тайван, урган цэцэглэг. Энэ тал бүрэн ойжихоор дээр үед чиний тэнэдэг байсан уулнаас баруун тийш чамд зөндөө нутаг нэмэгдэнэ.

Модон гунигтай болов.

- Ой ч яахав ургана, багсайтлаа ургана. Онтууд үгүй. Үр хүүхдүүд минь хаа байна?

- Одоо өөрийнхөө нутгаар эрж хай. Зүүн хязгаар руу зам нээлттэй болсон шүү дээ. Чамд хэн ч саад болохгүй.

Гэвч Модон гунигтайяа толгой сэгсрэв:

- Танихгүй тэр хязгаар хол байна даа. Тэнд хүн их олон болсон! За миний үг олдлоо, өршөөгөөрэй! Та нар манайхаар орж амраад явах юм уу? Фангорноор явж болно, зам дөтөлнө шүү дээ – гээд тэр Келеборн, Галадриэль хоёр руу харав.

Гэвч Леголасаас бусад нь цөмөөрөө гэр рүүгээ яарч байв.

- За за, Гимли, явъя! – гэж Леголас хэлээд – Фангорны өөрийнх нь зөвшөөрлөөр эндхийн бүх хонхроор орж, дундад газарт өөр хаа ч байхгүй аварга моддыг харна. Гимли чи хаашаа ч алга болохгүй шүү, ам мөнгөнөөс үнэтэй. Эхлээд Фангорноор Бөглүүд ойд хүрнэ, тэндээс танайх хүртэл ойрхон, хэдхэн харайгаад л орчихно.

Гимли зөвшөөрсөн боловч баярласан шинжгүй байв.

- За ингээд хадгалагч бидний баг тарлаа. Гэлээ ч гэсэн та нар маань манай нутагт удахгүй эргэж ирнэ гэж найдаж байна шүү - гэж Арагорн хэлэв.

- Биднийг явуулдаг л юм бол ирнэ, миний хөөрхөн хоббитууд ч гэсэн баяртай! Намайг бодож орон гэртээ амьд мэнд, бүрэн бүтэн харьж үзээрэй дээ. Та нараас болж санаа зовох гэж төвөг! Та нарт хэл хүргэнэ ээ, уулзаж ч мэднэ, харин бүгдээрээ цуглахгүй байх л гэж айж байна – гэж Гимли өгүүлэв.

Модон бүгдтэй ээлж дараалан салах ёс хийж, Келеборн, Галадриэль хоёрт машид хүндэтгэлтэй, яаралгүй гурвантаа мэхийн ёслов.

- Бид уулзалдалгүй мөн ч их удаж дээ, мод, чулуу л санаж байгаа байх. Гунигтай мэт боловч эцсийн эцэст уулзлаа. Одоо ч бүх ертөнц өөрчлөгдөж байна даа, газар дэлхий ч өөр болж, агаар ч гэсэн цаанаа л нэг өөр болж. За за, ямартай ч уулзлаа, дахиад уулзахгүй биз дээ.

- Тийм байх аа, Ахмад минь - гэж Келеборн хэлэв.

Галадриэль :

- Өнөөгийн Дундад газарт бид уулзалдахгүй. Тэнгисийн гүнээс живсэн Белериандын газар хөвөөд гарч иртэл. Харин тэр цагт Тасаринены бургасан ойд эхний хавар уулзаж магадгүй. Тэр уулзалт хүртэл баяртай!

Мерри, Пин хоёр хөгшин онттой хамгийн сүүлд салах ёс хийхэд тэр мань хоёрыг хараад хөгжилтэй болов:

- За сэргэлэн хоёр жаал минь, замд гарахын өмнө булгийн уснаасаа уух уу даа, аа?

- Дуртайяа ууя – гэж мань хоёр дуу нийлүүлэн хариулахад Модон тэр хоёрыг дагуулан өндөр модны сүүдэрт орж, том чулуун торхноос гурван эвэр дүүрэн ус аягалав. Хоббитууд яаралгүй уухад, онг ч өөрөө уух зуураа тэр хоёрыг нууцлаг том нүдээрээ ажиглаж байв.

- Болно, та хоёрт одоо хангалттай юм шиг байна, өмнөх уулзалтаас хойш ямар их өсөө вэ! – гэж тэр зальтайхан хэлэв.

Хоббитууд инээлдэн эвэртэй усаа хөнтөрлөө.

- За одоохондоо баяртай гэх үү дээ. Онтжингуудын тухай юм дуулдвал хэл өгөөрэй – гээд тэр аварга том гараараа далласаар моддын дундуур алга болов.

Тэд Ристанийн хаалгыг чиглэн давхисаар Пин нэгэнтээ ортханкийн чулуу руу хамраа дүрсэн тэр газарт ирээд Арагорноос салах болов. Хоббитуудын царай барайлаа. Арагорнтоой хичнээн ч хамт явж, хичнээн гай зовлонгоос тэр аварсан билээ дээ!

- Ээ дээ, бидэнд одоо тэр чулуу байдаг ч болоосой, алс хол байгаа найз нартайгаа ярьж байх юмсан! - гээд Пин санаа алдав.

- Үүний тулд зөвхөн нэг нь л хэрэг болно. Минас-Тиритийн нүдтэй чулуунд чи юу ч олж харахгүй, харлаа ч гэсэн ойлгохгүй. Ортханкийн чулуу эзэн хаанд хэрэгтэй. Тэр газар нутгаа харж, албат иргэдээ хараанаасаа алдахгүй байхад чухал. Харин чи Перегрин Молтогчин минь, Гондорын дайчин ван гэдгээ битгий мартчихаарай, би чамд хугацаагүй чөлөө олгосон боловч хэрэгтэй цаг ирвэл дуудна шүү. Түүнээс гадна миний эрхэм анд хоббитууд минь, умард газар ч гэсэн надад захирагдана, эрт орой хэзээ нэгэн цагт би танай нутгаар орно гэдгийг санаарай – гэж Арагорн өгүүлэв.

Арагорн дараа нь Келеборн, Галадриэль хоёртой салах ёс гүйцэтгэв. Хатан хаан түүнд:

- Эльфийн Берилл, харанхуй сарнилаа, чиний бүх мөрөөдөл биеллээ. Аз жаргалтай амьдраарай!

- Үүрд баяртай садан төрөл минь! Намайг дайрсан тавилан чамайг бүү дайрах болтугай, улс гүрэн чинь бүрэн бүтнээрээ байх болтугай! – гэж Клерборн ерөөлөө.

Тэд нэг бээр орчим яваад эргэж харахад эзэн хаан Элессар болон түүний баатар вангуудын хуяг дуулга оройн наранд алтран, Арагорн гараа өргөхөд ногоон берилл товч нь хурцаар гэрэлтэж харагдав.

Изен голын тохойгоор тойрон гарч ирэхэд дунландчууд эльфүүдийг хараад таран гүйлдэж, энд тэнд нуугдаж байлаа. Аянчид тэднийг огт анхаарсангүй, тэд довтлохгүй нь мэдээж. Тэд яаралгүй явж, хүссэн газраа асар майхнаа босгон амарч байлаа.

Арагорноос салснаас хойш зургаа дахь өдөр нь тэд манант уулсын баруун бэлд хүрлээ. Нар жаргах үед ойн захад гарч иртэл таяг тулж, бохир саарал навгас өмссөн өвгөн, бас нэг

гуйлгачин өвгөн хоёр үглэж ёолон явж байхтай тааралдав.

- Энэ чинь чи юу, Саруман! Хэрэг зориг хаашаа вэ? – гэж Гэндальф асуув.

- Чамд ямар хамаа байна? Урьдынхаа адил надад хаашаа явахыг заах нь уу, миний зовлонд цадаагүй юу? – гэж тэр хариулав.

- Хариултыг чи өөрөө мэдэж байгаа. Чамд заах гээгүй, чиний зовлонд баярлаагүй. Миний ажил дуусч байна. Одоо тэр талаар их хаан санаа тавина. Чи Ортханкад хүлээж байсан бол түүний өршөөл, мэргэн ухаан хоёрт бишрэх байсан юм даа.

- Ядаж амжиж гарсан минь яамай даа, тэр өөрийнхөө мэргэн ухаан, өршөөл хоёртоо хахаж үхэг. Чиний асуултад хариулья. Би тэрний улсын газар нутгаас гарч явна.

- Чи дахиад л буруу зам сонгож дээ. Ингээд хаашаа ч гарахгүй. Бидний тусламжаас чи татгалзсан хэвээрээ юу? Чамд тусалья гэж дахиад санал тавьж байна.

- Туслах ий? Надад уу? - хэмээн Саруман шүднийхээ завсраар сийгүүлээд: - Үгүй шүү, ингэж инээмсэглэхийн оронд ярзайсан чинь дээр байлгүй. Хатан хаанд чинь ч итгэхгүй. Тэр дандаа намайг үзэн яддаг байсан, тэгээд чамд хожоо гаргаж өгч байгаа юм. Одоо ч гэсэн миний мууг үзэх гэж та нарыг энэ замаар дагуулж яваа. Та нар араас минь хөөж явааг мэдсэн бол та нарын бахыг ингэж хангахгүй байсан даа.

- Саруман, бидэнд чамтай хөөцөлдөхөөс илүү чухал ажил зөндөө байна. Зүгээр л чиний аз болж, чамд аз сүүлчийн удаа гийж байна - гэж Галадриэль хэлэв.

- Хэрэв сүүлчийн удаа бол би баяртай байна. Дахиад гийхгүй бол сайн байна, баярлалаа. Миний аз хийморь ард хоцорсон, та нарынх надад хэрэггүй. Та нар тийм их азтай гэж үү? – гээд түүний нүд хорсолтой гялалзаж:

- Явцгаа, явцгаа! Би өчнөөн олон зуун жил номч байсан нь дэмий хэрэг биш шүү. Та нар нэгэнт өнгөрсөн, өөрсдийнхөө гараар өөрсдийгөө хөнөөсөн. Тэнэж явахдаа би та нар миний байшинг нураахдаа өөрсдийнхийгөө нураасныг чинь бодоод санаа амрах болно. Та нарыг тэнгисийн хязгааргүй орон зайд аваачих тэр хөлөг онгоц чинь юу юм бэ? – гэж тэр тавлан асуугаад:

- Тэр бол хий үзэгдлүүдээр дүүрэн саарал онгоц – гээд хяхтнан хөхөрснөө:

- Босооч мал аа! – хэмээн хашгирч, замын хажууд атиран сууж байсан дагуулаа таягаараа цохив:

- Түргэл, бид энэ дээдэстэй зам нийлэхгүй, буцахаас биш. Хурдал, тэгэхгүй бол чамд талхны үртэс ч өгөхгүй шүү!

Бөгтөр гуйлгачин уйлагнан босохдоо:

- Хөөрхий, хөөрхий муу хөгшин Грима! Зодоод л, загнаад л, загнаад л, зодоод л. Хараал

идээсэй чамайг! Яаж энэнээс нэг салъя даа байз! – хэмээн үглэв.

- Салаад л явчих, тэгээд л гүйцээ! – гэж Гэндальф хэлэв.

Гэвч Өмхий Амт Гэндальф руу нүдээ бүлтийлгэн харснаа айсандаа татвагасхийн Саруманы араас майжигнав. Саруман хоббитуудын хажууд ирээд, тэдэн рүү үзэн ядсан харц шидэхэд, цаадуул нь түүний өөдөөс өрөвдсөн харцаар ширтэж байлаа.

- Аа, өөдөснүүд хүртэл гуйлгачин өвгөнөөр даажигнах гэж ирээ юу? Өглөг өгөх юм биш биз? Ийм тарган цатгалан, гоё ганган хувцастай яваа юм чинь сайн тамхи зөндөө байгаа биз дээ. Хаанаас тамхи авсныг чинь мэдэж байна аа. Гуйлгачин өвгөнд чимх тамхи өгөхгүй юу, аан?

- Би баяртайгаар өгмөөр байна, даанч надад байхгүй - гэж Фродо хэлэв.

- Байз байз, надад жаахан үлдсэн - гээд Мерри мориноос бууж, богцоо уудлаад, Саруманд арьсан хүүдий өгч:

- Хичнээн үлдсэн байна, бүгд чинийх, Изенгардын нуранги дотроос олсон юм!

- Миний тамхи байна! Их үнэ төлж авсан юм шүү - хэмээн Саруман хүүдийг шүүрч авангаа дуу алдаад:

- Энэ ч яахав өчүүхэн өглөг юм биз, та нар тэнд ханаж цадтлаа дээрэмдсэн нь мэдээж. Өгсөнд нь баярлахаас яая гэхэв. Хулгайч хулгайлсан юмаа буцааж өгдөггүй гэдэг. Та нар өмнөд тойрогтоо очоод үзэх ёстой юмаа үзнэ ээ! Танай газар нутгийг тамхинд хордсон дутуу төрөгсөд олон олон жил бузарлах болтугай!

- Сайхан үг хэлсэнд баярлалаа! Харин хүүдийг минь өгөөтөх, наадах чинь чинийх биш, би дэвэн дэлхийгээр тэнэхдээ гээгээгүй юм, наад хороо өөрийнхөө навтас руу хий!

- Хулгайч хулгайчаа барьж идэх нь ээ - гээд Саруман шууд эргэж Өмхий Амтыг нэг өшиглөөд ой руу зүглэв.

- Мөн хуцав аа! Бид бас хулгайч болж таарав уу! Хэн бид хоёрыг отож бариад, гэмтээж бэртээж, Ристанийн нутгаар хөндлөн гулд чирч гүйсэн билээ? – гэж Пин эгдүүцэв.

- Тийм ээ! Их үнэ төлсөн гэж хэллээ. Юугаар төлбөр хийснийг нь мэдэх юмсан. Өмнөд тойргийн тухай ерөөл нь надад огт таалагдсангүй. Хурдхан харих хэрэгтэй болох нь дээ.

- Хурдханаас ч хурдан л очмоор байна. Гэвч Бильботой уулзахаас нааш явахгүй. Юу л болвол болог, ямар ч байсан эхлээд Уудам хөндий орё.

- Зөв байна. Саруман сайн юм юу ч хийхгүй, үндсээрээ ялзарсан байна. Модон алдсан байх гэж би айж байна. Тэр санаандаа орсон муу үйлийг гүйцэлдүүлэх чадалтай хэвээрээ байна – гэж Гэндальф хэлэв.

Маргааш нь умард Дунландын эзэнгүй нутагт оров. Есдүгээр сар болж, өдөр нь алтлаг

шаргал, шөнө нь мөнгөлөг цайвар, өвс ургамал өтгөн. Хүрхрээнээс зүүн тийш, хуучин гармын ормоор Хунт гол дээр ирэв. Гол олон салаалж, мушгиран урссаар Саарал урсгал голтой нийлэх бөгөөд зах нь үл харагдах зэгсэн шугуйд хунгийн сүргүүд үүрээ засчээ.

Тэд нэгэн намхан толгой дээр хоноглов. Өглөө болоход мананд хучигдсан Остранна гол, зүүн талд Карадраса, Келебдора, Фануиндхолын үүлэн цаадах оргилууд үзэгдэж, Морийн хаалга ойрхон харагдав. Энд тэд долоо хоног өнгөрөөгөөд дахин гунигт салалт боллоо. Келеборн, Галадриэль хоёр дагуулуудтайгаа зүүн зүг эргэж, Хүрэн хаалга, Хар гол, Мөнгөлөг голоор дамжин Лориэн руугаа буцах цаг болов. Тэд Гэндалф, Элронд хоёртой ханатлаа ярилцахын тулд тойруу зам сонгосон ажээ. Тэдний ярианд эцэс төгсгөл байхгүй юм шиг санагдана. Хоббитууд одтой тэнгэрийн дор сууж, өнгөрсөн үеийн үйл явдлуудаа дурсан, ирээдүйн тухай хэлэлцдэг байлаа. Хэрэв тэдний хажуугаар тохиолдлын аянчин явж өнгөрвөл эзэнгүй газарт үлдсэн өнгөрсөн үеийн дурсгал – саарал баримлуудаас өөр юу ч үзэхгүй, юу ч сонсохгүй байсан биз ээ. Учир нь тэд хөдлөх ч үгүй, дуугарах ч үгүй, зөвхөн үгээр хүч нэмэгдүүлээгүй санаа бодол нь нэг болон нийлж, нүд нь заримдаа очис цацруулж, заримдаа намуухан туяа гийж байлаа.

Ингээд ярих юмаа ярьж дуусаад, Эльфийн гурван бөгжний хугацаа дуусах хүртэл дахин салах боллоо. Саарал нөмрөгтэй Лориэний эзэд болон дагуулууд нь хад асганы завсраар үзэгдэхтэй үгүйтэй холдон одов. Уудам хөндий орох ёстой бусад нь толгой дээр суугаад, тэдний араас харж байлаа. Өтгөрч байгаа мананг нэвтрэн одод гялалзахад Фродо бидэн рүү Галадриэль гараараа даллаж байна гэж ойлголоо.

Сэм эргэж хараад санаа алдав:

- Ээ дээ, Лориэнд дахиад нэг очихсон.

Хэд хоногийн дараа тэд нэгэн бутархаг толгой дээр гарч иртэл, Элрондын гэрэлт өргөө урьдын адил гэнэт нүдний өмнө гарч ирэв. Тэднийг хаалганд дөхөж очтол өргөөний гэрэл мэлсхийтэл асч, мэндчилгээний дуу уянгалав.

Хоббитууд замын тоосоо ч унагалгүй, хоол ч идэлгүй Бильбог хайж, цаас бичиг замбараагүй овоолсон, өд, харандааны өөдөс хөглөрсөн жижиг өрөөндөө сууж байхад нь орлоо. Тэр өөрөө улалзан асч байгаа задгай зуухны дэргэд сууж байлаа. Тэр маш их хөгширсөн, маш их тайван, нойрмог байлаа.

Тэднийг бөөнөөрөө орж очиход Бильбо нүдээ олнийлгон өлийж хараад:

- Сайн байцгаана уу, хүрээд ирээ шив дээ! Ингэхэд маргааш миний насны ой болно шүү. Сайхан тааруулж ирлээ дээ! Би одоо нэг зуун хорин ес хүрч байгааг мэдэж байна уу? Дахиад нэг жил тэсчих юм бол Хөгшин Молтогчинг гүйцнэ. Тэрнээс түрүүлчихвэл сайн л байна. Амьд байвал үзнэ биз дээ- гэлээ.

Өвгөний насны ойг тэмдэглэж, дөрвөн хоббит Уудам хөндийд хэд хоног саатав. Тэд Бильбогийн жижиг өрөөнд ихэнх цагаа өнгөрүүлэв. Тэр зөвхөн хоол идэх гэж л өрөөнөөсөө гарна. Хоолны цагийг андана гэж байхгүй. Нойр нь тэр дорхноо сураггүй болно. Хоббитууд

аян замын паянгаа ээлж дараалан ярина. Тэр эхэндээ тэмдэглэж авч байгаа дүр үзүүлэвч байсхийгээд л унтаад өгнө. Сэрэнгээ:

- Мөн хачин аа! Итгэмээргүй юм! Та нар юу гэж ярьсан билээ? – гэж асууна.

Тэд өвгөний унтсан газраас яриагаа үргэлжлүүлнэ. Арагорны хаан ширээндээ заларсан, хурим хийсэн тухай л давтаж ярих хэрэг гарсангүй. Өвгөн тэр тухай бараг нүдээ цавчилгүй сонсов.

- Намайг тэр хурим руу чирж явахаа дөхсөн. Би ч эртнээс хүлээж байсан юм. Яг явах болоход ажил толгойтой үснээс их болчихсон.

Хоёр долоо хоносны дараа Фродо өглөө цонхоор хартал шөнө хүйтэрч, аалзны шүлсэн торнууд мөнгөлөг өнгөөр хяруутсаныг үзэв. Явах цаг болжээ гэсэн үг. Гайхамшигтай сайхан зуны дараа намуухан, тодхон тунгалаг намар болж, аравдугаар сард ч гэсэн салхи үлээж, бороо асгарч байлаа. Уудам хөндийгөөс Хоббитани ортол урт зам туулах хэрэгтэй. Цаг агаар өөрчлөгдсөнд ч биш, ер нь даруй явах хэрэгтэй гэж тэр мэдрээд байв. Сэм ч сэтгэл нь дэгэлзэж:

- Эзэн минь, бидэнд яваагүй газар, үзээгүй юм алга боллоо. Энд хичнээн сайхан байсан ч явах цаг болсон юм биш үү, аан? Миний муу Жихарь, үнэнээ хэлэхэд, толгойноос гардаггүй.

- Тийм ээ Сэм, энд юм бүхэн бага багаар байна, ганцхан тэнгис л алга – гэж Фродо хариулаад дотроо: “Зөвхөн тэнгис л алга” – гэж давглаа. Тэр өдөр Фродо Элрондтой яриад маргааш өглөө замдаа гарахаар шийдэв. Гэндальф:

- Би та нартай ядаж Уулын суурин хүртэл хамт явъя, Наркисстай уулзах хэрэг байна – гэж тэднийг баярлуулав.

Тэд шөнө нь Бильботой салах ёс гүйцэтгэхээр орлоо.

- Явах хэрэгтэй бол явалгүй яахав. Та наргүйгээр надад уйтгартай л байх болно доо. Гэхдээ миний нойр байнга л хүрээд байх юм – гэж өвгөн хэлэв.

Тэр Фродод мифрил хуяг, Терн илдийг аль эрт бэлэглэснээ мартаад дахин бэлэглэв. Бас олон жилийн хөдөлмөр нь болсон дуу, домгийн гурван ном бэлэглэв. Номууд нь жижигхэн үсгээр бичсэн гар бичмэл бөгөөд улаан хавтсан дээр нь “Эльф хэлнээс орчуулав. Б.Т.” гэж гоёмсог бичжээ. Сэмд тэр хүүдийтэй алт бэлэглэв.

- Смаугаас үлдсэн юм бараг л энэ байсан юм. Гэрлэх гэж байгаа бол хэрэг болно - гэв.

Сэмийн нүүр гэрэлтэн улайв.

- Харин та хоёрт бэлэглэх юм алга. Сайн зөвлөгөөг бэлэг болгож ав хэмээн Мерри, Пин хоёрт хандаж, баахан зөвлөгөө өгөөд дараа нь хоббитийн ёсоор үгээ дуусгаж:

- Та хоёр хамаагүй цухалзаад байж болохгүй, хамар руугаа нулиулбал яана! Бас хэтэрхий

өссөн байна, гутлаа өмсөхөд хэцүү болно – гэв.

- Өөрөө болохоор Хөгшин Молтогчинг давж насална гээд байгаа, бид хоёр Бандобрас Буханминжийн хамрыг сунгамаар байна – гэж Пин хэлэв.

Бильбо тачигнатал инээгээд халааснаасаа мөнгөн хээ угалзтай, сувдан соруултай хоёр гаанс гаргаж ирэв.

- Эльфийн уран хийц. Би одоо ямар тамхи татах биш. Тамхиа асаахаараа намайг дурсч байгаарай! – гээд тэр хоёрт гардуулснаа тонголзон үүрэглэв. Тэр дороо сэрээд:

- Бид юу гэж ярьж байлаа? Аа тийм, бэлэг өгч байсан шүү дээ. Ингэхэд Фродо, би чамд бөгж бэлэглэсэн шүү дээ, тэрийг яасан бэ?

- Бильбо минь, намайг уучлаарай, би тэрнийг хаячихсан, хаясан ч гэж дээ, тэрнээс хагацсан.

- Харамсалтай л байна, би тэрнийг дахиад нэг харья гэж бодсон юм. Өө нээрэн тийм л дээ, би будилж байна. Чи тэрнээс хагацах гэж л явсан шүү дээ, тийм байх аа? Бүр будилж гүйцэх юм, бүх юм холион бантан. Та нарын ярьсан юмнууд дунд толгой эргэж гүйцлээ. За одоо суугаад өөрсдийнхөө тухай сонс, та нар ч шившгээ хутгаагүй шүү. Задгай гал асч байна, сайхан хоол өгч байна, юм л болвол эльфүүд дэргэд зогсч байна. Өөр надад юу хэрэгтэй юм бэ?

Харгуй зам ердөө

Хаалганаас алслан зурайж байна.

Хэн тэр замаар явна,

Хэн тэр замаар ирнэ -

Хамаа алга надад.

Хэн хүснэ вэ, тэр

Холын замдаа гараг.

Харин би замаас гарч,

Хажуугийн мухлагт сууж,

Халуун зуухны дэргэд зүүрмэглэе.

Дууныхаа сүүлчийн мөрийг Бильбо аялах ч биш, бувтнах ч биш давтаад бөх гэгч нь унтаад өгөв.

Үдшийн бүрэнхий өтгөрч, зуухны гал улалзан, тэд унтаж байгаа Бильбог, түүний тайван

инээмсэглэлийг харж зогслоо. Сэм өрөөг тойруулан хараад, аяархан хэлэв:

- Ноён Фродо, биднийг явснаас хойш энэ хүн дэндүү их юм бичжээ. Бидний туужийг бичиж амжихгүй л болов уу даа.

Бильбо түүний үгийг сонссон мэт нэг нүдээ нээгээд, буйдан сандалд тухлан суув:

- Ингээд л нойр хүрээд байдаг юм. Бичих юм бол шүлэг бичсэн нь дээр ч юм уу. Фродо, эрхэм анд минь, чи миний өрөөг жаахан янзлаад өгөхгүй юу? Энэ цааснууд, тэмдэглэлүүд, миний өдрийн тэмдэглэл гээд бүгдийг авахгүй юу, аан? Би янзлах зав гараагүй юм. Сэм чамд чадахынхаа хэрээр тусална. Нэг юм болгочихоод аваад ирэхгүй юу, би харья, гэхдээ шүүмжлэхгүй.

- Тэгэлгүй яахав! Удахгүй хүрээд ирнэ, тэр бол аян биш, зугаалга болох юм чинь. Эзэн хаан санаа тавина, тэрнийг байгаа цагт надад бүх зам чөлөөтэй – гэж Фродо хэлэв.

- Чамд баярлалаа, хонгор минь! Санааг минь амраалаа - гээд Бильбо бүр ч бөх нойрсов.

Маргааш нь Гэндалф болон хоббитууд Бильбогийн өрөөнд орж, түүнтэй салах ёс хийгээд дараа нь Элронд болон түүний гэрийнхэнтэй салах ёс хийв. Фродо гадаа гарахад Элронд түүнд сайн явахыг ерөөгөөд, аяархан хэлэв:

- Фродо, чи өнөө маргаашгүй наашаа ирэх гэсний хэрэггүй биз. Ирэх жил алтан навчис хараахан унаагүй жилийн энэ улиралд чи Бильботой Хоббитанийн ойд уулзана. Би түүнтэй хамт очно - гэлээ.

Элрондын энэ үгийг ганцхан Фродо л сонсож, тогтоож авчээ.

Бүлэг 17

Гэрийн зүг

Одоо тэдний зам шууд баруун зүг, Уулын суурингаар дайран Хоббитан руу зүглэв. Тэд төрсөн нутгаа дахин харах гэж тэсч ядан байсан ч эхэндээ удаан явж байв. Фродо бүр туйлджээ. Бруинений гармын дэргэд тэр шаасан гадас мэт зогсч, нүд нь амьгүй мэт гөлийв. Тэр өдөр Фродо нэг ч үгүй хэлсэнгүй. Аравдугаар сарын зургаан байсан юм.

- Чиний бие нэг л базаахгүй байна аа даа, Фродо? – гэж Гэндальф түүнд дөхөж очоод аяархан асуув.

- Тийм ээ, базаахгүй байна, шархтай мөр мэдээгүй болж, эргэн тойрон харанхуй болсон шиг санагдаад байна. Тэр өдрөөс хойш яг нэг сар болжээ.

- Зарим шархыг илааршуулж болдог ч эдгээж болдоггүй юм даа – гээд Гэндальф санаа алдав.

- Минийх тийм шарх байх аа, надад буцах зам байхгүй болох вий гэж айж байна. Хоббитанид очиход эх нутаг минь огт өөр болчихсон байна, яагаад гэвэл би хуучин Фродо биш болсон. Би хорлогдож, эрэмдэг болсон. Дайсны илд, Шелобын хатгуур, Хорлумын шүд... хүнд бөгөөд авч хаяж болшгүй ачаа дарж байна. Хаана очвол амгалан тайван болох бол?

Гэндальф дуугарсангүй.

Маргааш нь түүний өвчин намдаж, уйтгар гуниг арилан, Фродо саяхны хар зовлонг мартсан мэт дахин хөгжилтэй болов. Өдөр хоногууд анзаарагдалгүй өнгөрч, тэд сийрэгжсэн хүрэн, шар өнгийн навчист хучигдан, намрын наранд нэвт гийсэн ойд удаан амарлаа. Эцэст нь Эргүүлэг ууланд хүрч ирэв. Орой болж, уулын бараан сүүдэр зам хааж байх мэт санагдана. Фродо нөхдөө хурдал гэж хэлээд, уул руу харалгүй, нүүрээ цувныхаа энгэр рүү шургуулан сүүдэр дундуур давхиж өнгөрөв. Тэр шөнө цаг агаар муудлаа. Баруунаас хүйтэн, ширүүн салхи бороотой хавсран шавхуурдаж, эргэн тойронд шар навчис айсан сүрэг шувуу шиг хийснэ. Четборт модод бараг нүцгэрч, Уулын сууринг будантсан бороон хөшиг хааж байлаа.

Таван аянчин Уулын суурины өмнөд хаалганд хүрч ирсэн аравдугаар сарын хорин наймны орой цаг агаар чийглэг хүйтэн байв. Хаалга тас түгжээтэй, нүүр рүү бороо шавхуурдаж, хөвж буй үүлсийн доорх намхан тэнгэр хуйсгануур царайтай байлаа. Хоббитууд бага зэрэг урам муутай байв. Ямар ч гэсэн тэд ийм найрсаг биш угтах гэм хийгээгүйсэн билээ.

Хашгирч, нүдсэний эцэст хаалга нээгдэж, бүдүүн бороохой барьсан манаач үзэгдэв. Тэр аянчид руу айсан, сэжиглэсэн нүдээр ширтэж, дараа нь Гэндальфыг баахан хараад түүнтэй хамт яваа хачин төрхтэй хоббитуудыг хүлээн зөвшөөрөв бололтой:

- Орцгоо, орцгоо, та нар замбараагүй их шинэ сонинтой яваа биз, бидэнд ч бас дуулгах сонин зөндөө л байна, хэдэн үг солих юмсан, даанч энэ тэнгэрийн байж байгаа царай энэ. Хүйтэн бороо асгараад л... Лаврик мэдээж та нарыг “Дүүхэлзэж буй пони морь”-тоо байрлуулна,

Тэнд бүгдийг ярьж, сонсоно биз дээ.

- Чи ч гэсэн оройхон шиг тийшээ орохгүй юу, бүгдийг мэдэж аваад бас дээр нь илүү дэлүү юм ч чагнахгүй юу, тийм биз дээ? - гэж Гэндалф тачигнатал инээгээд: - Танай Горри ямаршуу амьдарч байна даа?

Манаачийн царай барайв.

- Горри манай энд амьдардаггүй – хэмээн тэр бувгнаад – Та Лавраас асуугаарай, тэр бүгдийг яриад өгнө. За оройг сайхан өнгөрөөгөөрэй!

- Чи ч гэсэн! – гэж хэлээд тэд цааш явахад замын хажуугийн хайсны цаана урт сарай барьсныг ажиглав. Тэндээс хүмүүс гарч ирээд хашааны цаана бөөгнөрөн тэднийг харж байв. Цохиур бургаасны байшингийн хажуугаар өнгөрлөө. Хашаа нь тэр чигээрээ нурж, зэрлэг ургамалд эзлэгдэн, цонхнуудыг модоор таглаж хаджээ.

- Сэм чи тэгэхэд яасан бэ, идэж байсан алимаа ам руу нь нээрэн хийчихсэн юм уу? - гэж Пин сониучирхав.

- За үгүй дээ ноён Перегрин, юу гэж хэлмээр юм бэ дээ, үгүй л болов уу - гэж Сэм бодлогошронгуй өгүүлээд – Миний муу морь, пони минь амьд л байдаг байгаа даа. Зугтаачихсан. Тэгэхээс өөр яах билээ. Чононууд улилдаад байдаг, амьдармаар байдаг...

“Дүүхэлзэж буй пони морь” – ны үүдэнд хүрээд ирлээ. Тэнд бүх юм урьдын адил байгаа бололтой, доод давхрын цонхнууд хүрэн хөшигний цаанаас гэрэлтэж харагдана. Тэд хонхны оосроос татахад хаалга хагас нээгдэж, Ноб шагайсанаа тэдэн рүү дэнлүү тусгаж хараад байдаг хоолойгоороо хашгирлаа:

- Ноён Наркисс! Эзэнтээн! Тэд эргээд ирлээ!

- Эргээд ирлээ гэнэ ээ? Одоохон би тэдэнд үзүүлээд өгье! - гэж Наркиссын дуу гарснаа өөрөө бороохой барьсаар гарч ирэв. Гэвч тэднийг хараад нам зогсч, уур хилэнт царай нь тэр дорхноо гайхсан, баярласан хоёр зэрэгцэв:

- Чи муу тэнэг мал, үстгавхай Ноб! –хуучин андуудаа танихгүй, нэрийг нь мэдэхгүй байгаа вий? Намайг бүр сандаргаж орхилоо байна, тэнэг минь чи одоо ямар цаг вэ гэдгийг мэдэж байгаа шүү дээ! Бурхан минь, хараач хөөе! Та нар ямар хачин улс вэ? Би та нартай үүрд салах ёс хийгээ биз дээ, Тэнэмэлтэй цуг оргүй хоосон руу явчихаа биз дээ, энэ чинь, ай ай, эргэн тойронд элдэв хачин хар морьтууд шиншлээд л. Та нарыг хараад би ямар их баярлаж байна аа, ялангуяа Гэндалфыг. Морилцгоо, морилцгоо! Нөгөө л өрөөнүүддээ орох уу? Та нарын өрөөнүүд сул байгаа. За ер нь бараг бүх өрөө хоосон байгаа даа, өөрсдөө харна биз. Оройн хоолны талаар одоо арга бодъё, одоохон, харин миний үйлчлэгч гэж одоо...

- Хөөе чи, хожуул Ноб оо! Бобод хэл... өө мартчихаж, Боб юу ч гэсэн өнөөдөр өөрийнхөнтэйгөө хоноё гээд явсан. Нэг үгээр хэлэхэд, Ноб, хөөе чи, морьдыг жүчээнд оруул. Харин Гэндалф, өөрийнхөө морийг өөрөө оруулаарай, тэр чамаас өөр хүний үгэнд орох

биш. Мөн ч сайхан морь доо, ямар сайхан морь вэ гэдгийг би тэгэхэд чамд хэлж байсан даа, хүүе та нар орооч ээ! Орцгоо, гэртээ байгаа юм шиг байцгаа!

Ноён Нарцисс амьсгаа авах завгүй урсгаж ярьдаг зан нь хэвээрээ боловч, ам хамхилгүй ярих завсраа ажлаа амжуулдаг нь бас хэвээрээ байлаа. Дэн буудлын өрөөнүүдэд бараг нэг ч хүн байхгүй, нийтийн танхимаас л хоёр гурван хүний аяархан ярилцах сонсдож байв. Эзэн хоёр лаа авчирч асаагаад тэдний өмнө тавих зуур нүүр өөд нь харвал нэлээд үрчлээ сууж, хөгширсөн харагдав.

Тэрбээр аянчдыг дагуулан коридороор нэг жилийн өмнө нэгэн түгшүүрт шөнийг өнгөрөөсөн доод мухрын өрөө рүү явахад түүний сэтгэл нэг л түгшүүртэй мөртөө тайван царай гаргаж байгаа мэт, байдал хуучныхаас огт өөр болсон шиг санагдаж байсан ч тэд юу ч хэлэлгүй хүлээж байв.

Тэдний хүлээж байсан нь зөв болж, оройн хоолны дараа ноён Нарцисс тэднийг хэр зэрэг тав тухтай байгааг үзэхээр орж ирэв. Тэд ч сэтгэл хангалуун байв. “Дүүхэлзэж буй пони морь” дэн буудалд төдийлөн өөрчлөлт гарсангүй, пиво, амтат хоол нь хэвээрээ л байна.

- Өнөөдөр би танарыг нийтийн танхимд оруулах бодолгүй байна. Та нар замдаа ядарсан, тэгээд ч өнөө орой тэнд олон хүн байхгүй. Гэвч та бүхэн орондоо орохын өмнө надтай хагас цаг суувал ямар вэ, би та нартай жаахан ярьж суумаар байна, өөрсдийнхөө амьдралын тухай л ярих гэсэн юм л даа.

- Бид ч бас яг л ингэж хүсч байна. Бид ядраагүй, биеэ зүдрээлгүй тааваараа явж ирсэн. Бид норсон, даарсан, өлссөн. Гэвч та биднийг хуурайлж, дулаацуулж, цатгалаа. Суугаач дээ! Харин та нэг нэрэх тамхи аваад ирвэл ч бид таны төлөө бурханд залбирна шүү – гэж Гэндалф хэлэв.

- Тэгэлгүй яахав, та нар надаас юм гуйвал би их баярлана шүү дээ. Гэхдээ байхгүй юм бол байхгүй шүү дээ, бид юм юмаар л дутагдаж байна, өөрсдийнхөө ургуулсан ногоогоор л болгож байна, энэ хангалтгүй шүү дээ. Одоо Хоббитаниас хэн ч ирэхээ больсон. Гэвч би чадах бүхнээ хийнэ ээ – гээд Нарцисс гарав.

Тэр эргэж ирэхдээ мань таван тамхичинд нэг хоёр хоног хүрэлцэх хэмжээний тамхины хэрчээгүй навчнууд авчрав.

- Өмнөд тойргийнх, бидэнд байгаа хамгийн сайн тамхи даа, гэхдээ өмнөдөөс наймаачид үзэгдэхээ больж дээ, би юу л ярина сууриныхны гачигдал зовлонг яриад байх юм, өршөөгөөрэй та нар минь.

Тэд ил галын дэргэд том буйдан сандал ойртуулж эзнийг суулгаад, Гэндалф галын нөгөө талд түүний өөдөөс харж суун, хоббитууд тэр хоёрын хооронд жижиг мухар сандал тавьж сууцгаав. Тэгээд тэд хагас цаг биш, бүтэн хагас цаг ярьж, ноён Наркиссын сонсохыг хүссэн бүхнийг ярьж, ярихыг хүссэн бүхнийг яриу. Тэдний ярьсан бүхэн дэн буудлын эзний чихийг дэлдийлгэж, нүдийг бүлтийлгэж байлаа. Тэдний яриаг сонсож байхдаа “Та юу хэлнэ вэ? Тийм юм гэж байх уу?” гэсэн үгс амнаас нь үл сална. “Больж үз, мистер Гэндалф! Тийм юм

гэж байх уу? Би л бол хэзээ ч үгүй! Манай энэ үед тэгж бодож болно гэж үү?” гэх мэтээр нүд нь төгрөг болтлоо бүлтийж, духан дээрээ гарах шахна.

Гэвч тэр Уулын суурины амьдралын талаар зөндөө их мэдээлэл өгөв. Хуучны сайхан цагийг бодвол амьдрал, юм бүхэн хавигүй дор орсон гэнэ. Бизнес өөрийнхөө замаар явахаа байж, бүр доошоо уруудаж байна.

- Уулын сууринд гаднаас хүн ирэхээ болилоо. Нутгийн хүмүүс голдуу гэртээ сууж, хаалга үүдээ түгжээтэй байлгаж байна. Энэ бүхэн ноднин жилээс хойш Их замаар цуварсан шинээр ирэгсэд, дээрэмч тонуулчдаас болж байгаа юм. Та нар тэднийг мэдэж байгаа. Зарим нь сүүлд ирсэн. Тэдний зарим нь дайны аюул заналаас дайжиж явааа ядарч зүдэрсэн хүмүүс боловч ихэнх нь хулгайч, худалч муу хүмүүс байсан. Уулин сууринд үнэхээр түгшүүртэй байна шүү, маш бэрх байна. Бид үнэхээр зовж байна, хэрэв та нар миний үгэнд үнэмших юм бол бүр хүмүүсийг хөнөөсөн явдал ч гарсан шүү гэж ярив.

- Би үнэмшиж байна аа, хэдэн хүнийг хөнөөсөн бэ? – гэж Гэндальф асуув.

- Гурван хүн, хоёр жижиг биет. .. Цөмөөрөө сайн хүмүүс байсан, тэд зүгээр л алга болчихсон. Баруун хаалганд байсан Гарри Ямаанчихт, Цохиур Бургаас хоёр тэнүүлчдийн араас ирээд тэднийг дагуулж явсан, тэр хоёр л тэднийг егүүтгэсэн байж таарна гэж би боддог юм. Байлдаан болдог шөнө шүү дээ. Тэгээд бид тэр хоёрыг суурингаасаа хөөж явуулсан. Он дуусахаас өмнөхөн болсон явдал, манай энд их цас орсны дараахан шинэ жилийн баяраар байлдаан болсон юм – гэж Нарцисс ярив.

- Одоо тэр хоёр хойт зүгийн зэлүүд газар, Арчетийн цаадах ой модонд нуугдаад, дээрэм хийж байгаа гэсэн. Энэ бол хуучны цөвүүн цагийн домогт гардаг шиг муухай явдал гэж би бодож байгаа юм. Одоо зам дээр их аюултай болсон, хэн ч хол газар явахаа больсон, айлууд үүд хаалгаа эртхэн түгждэг болсон. Бид хашаа хороо болгонд өдрийн цагаар харуул гаргаж, шөнийн цагт хаалган дээр олон эрчүүдийг харуулд гаргаж байна.

- Гэхдээ бид нарыг ойгоор явахад хэн ч биднийг айлгаагүй. Бид ойгоор удаан явсан, тэгэхэд ямар нэг түгшүүртэй юм ажиглаагүй. Бид аюул занал бүхэн ард хоцорлоо гэж бодож байсан шүү дээ – гэж Пин хэлэв.

- Тэр аргагүй шүү дээ, та нар шидтэнтэй хамт яваа юм чинь. Хэрэв та нар ганц нэгээрээ явсан бол гайхах юмгүй байлаа. Тэд илд зүүж, дуулга өмсч, бамбай барьсан зэвсэгт хүмүүс рүү дайрахгүй. Би та нарыг үзээд маш их гайхсан шүү.

Хүмүүс тэднийг хараад алмайран гайхаж байгааг хоббитууд сүүлд нь мэдсэн юм. Хүмүүс тэдний өмссөн хувцас, агссан зэвсгийг хараад гайхаж байгаатайгаа адил тэдний эргээд ирснийг үзээд мэл гайхаж байлаа. Тэд өөрсдөө дайн тулааныг үзэхээрээ нэг болж, дайчин баатруудын дунд морин дээр өдөр шөнөгүй давхиж байсан болохоор энийг юман чинээ бодохоо больж, цувныхаа дотуур хөө хуяг өмсч яваагаа, нутагт ингээд очих юм бол ер бусын гойд сонин харагдах Гондорын болон Маркийн дуулга, бамбай дээрх дүрс зэргээ бараг мартчихсан байв. Гэндальф ч гэсэн гайхамшигт өндөр саарал морио унаж, мөнгөлөг цэнхэр жанчаа намируулан, урт Яррист илдээ зүүж яваа билээ.

Гэндальф инээж - Зөв, зөв, хэрэв тэд нар бид таваас айж байгаа юм бол бид аян дайны замдаа тэр байтугай дайснуудтай тулалдаад дийлж ирсэн юм. Гэхдээ тэр муусайнууд та нарыг шөнө тайван унтуулахгүй байж дөнгөж л байгаа юм байна даа – гэв.

- Хэдий болтол ингэж байх юм бэ? Та нар энд хэсэг зуур байвал би мөн ч их баярлах байна даа. Бид урьд нь ингэж айж сандарч байгаагүйг та нар харж байна, мөрчид бүр их хол явчихсан гэж хүмүүс надад хэлсэн. Тэдний бидний төлөө байгуулсан гавьяаг бид урьд нь зөвөөр ойлгодоггүй байж, одоо явчихсан хойно нь л ойлгож байна. Дээрэмчдээс ч илүү аюултай дайсан байна. Өнгөрсөн өвөл чононууд хашаан дээгүүр өнгийж хардаг байсан. Ой дотор хар сүүдрүүд тэнэж явааг харахаар цус царцах шиг болдог юм. Хэрэв та нар миний яриаг ойлгох юм бол үнэхээр хэцүү байна.

- Ийм юм болно гэж би мэдэж байсан юм аа. Ерөнхийдөө бүх Дундад газар энэ үед түгшүүртэй байна, маш их их түшүүртэй байна. Гэвч өөдрөг бай, Наркисс минь! Та нар маш том аюулын ирмэг дээр байна, гэвч та нар үүнээс доош орчихоогүй байгааг чинь сонсоход надад сайхан байна. Сайхан цаг ирж яваа. Магадгүй, та нарын урьд өмнө хэзээ ч үзээгүй сайхан цаг ирж байна. Мөрчид эргэж ирнэ. Бид ч бас тэдэнтэй хамт эргэж ирнэ. Хаан чинь ч ирнэ, Нарцисс! Тэр мөдхөн бодол санаагаа нааш нь хандуулна.

Тэгээд Их зам дахин нээгдэнэ. Түүгээр умар зүг олон элч нар цувна, нааш цаашаа зөндөө хүн явна, энэ уудам газраас шулмын хорлол холдон зайлна. Үнэндээ одоогоор л буйдхан зэлүүд газар байгаа болохоос биш удахгүй өөр болно, одоо зэлүүд байгаа энэ газарт олон хүмүүс суурьшина – гэж Гэндальф ярилаа.

Ноён Нарцисс толгойгоо дохив.

- Хэрэв Их зам дээр хэдэн хүндтэй хүн гаргачихвал айж түгших юм байхгүй болно л доо. Гэхдээ бид дайн тулаан дахиж бүү болоосой гэж бодож байна. Бид бас Уулын сууринд болон суурины ойролцоо харийнхныг байлгамааргүй байна. Бид өөрсдөө л эндээ баймаар байна. Энэ газарт маань үй олон тэнүүлчид бөөгнөрч, энд суурьшин онгон зэлүүд нутгийг маань сүйтгэхийг би хүсэхгүй байна.

- Та нар эндээ өөрсдөө л байх болно. Танай энд урд, хойноос ирсэн зочдод хангалттай хүрэлцэх өрөө байна, тэдний нэг нь ч Уулын сууринд удаан суухыг хүсэхгүй. Ихэнх ирэгсэд хойт зүг рүү явна, эндээс хэдэн зуун бээр, түүнээс ч хол явж одно, их замын үзүүр хүртэл явна - гэж Гэндальф хэлэхэд:

- Үхмэл нуур хүртэл үү? – гэж Нарцисс улам ч эргэлзэнгүй асуугаад – Тэр чинь сөнөсөн газар гэсэн шүү дээ. Ямар ч дээрэмчин тийшээ явахгүй дээ гэж эргэлзэнгүй өгүүлэв.

- Чиний Үхмэл нуур гэж хэлсэн тэр газар руу мөрчид очдог юм. Олон жил тэр газрыг ингэж нэрлэж байгаа боловч үнэн нэр нь Форност Эрайн буюу Хаадын чуулган гэдэг юм. Хаан энд мөдхөн нэг л өдөр хүрээд ирнэ, тэгэхэд та нар их баяр хийх болно доо.

- Ойлголоо. Энэ чинь их найдвар төрүүлж байна. Би дэмжиж байна, тэгвэл бизнест минь сайн болно гэдэг эргэлзээгүй. Хаан Уулын сууринг их удаан орхилоо.

- Тэр ирнэ ээ, тэр та нарыг мэднэ, та нарт хайртай – гэж Гэндальф хэлэв.

- Тэр одоо ирнэ гэж үү? Эндээс хэдэн зуун бээрийн цаана, агуу шилтгээн дотроо, асар том буйдан сандал дээр суугаад алтан хундаганаас дарс шимж суугаа тэр наашаа яах гэж ирэхийг нь хэлж мэдэхгүйдээ би итгэлтэй байна. Түүнд “Дүүхэлзэж буй пони морь”, пиво хоёр ямар хэрэгтэй юм бэ? Миний пиво сайхан пиво учраас гэж би бодохгүй байна Гэндальф. Чи өнгөрсөн жилийн намар ирж, сайхан үг хэлээд явснаас хойш юм бүхэн сайхан байгаагүй. Энэ бол айдас төрүүлсэн сайхан ам гэж би хэлмээр байна.

- Өө тийм үү? – гэж Сэм ярианд оролцоод - Гэхдээ тэр чиний пивийг ямагт сайхнаараа байдаг гэж хэлсэн юм шүү.

- Хэн хэлсэн гэж?

- Хаан хэлсэн юм. Тэр бол Тэнүүлч. Тэр бол мөрчдийн ноён. Чи тэрний толгой дахь бодол руу өнгийж хараагүй юм уу?

Нарцисс мэл гайхаж хоцров. Түүний өргөн нүүрэн дээрх хоёр нүд нь дүгрэглэн томорч, ам нь байдгаараа ангайсан чигтээ гацав. Тэр эцэст нь амьсгаагаа авангуут “Тэнэмэл” гэж дуу алдлаа.

- Тэр одоо алтан титэмтэй хаан болоод ирэх нь байна шүү дээ. Тэгвэл бидэнд юу ирэх вэ ?

- Сайхан цаг ирнэ – гэж Гэндальф хэлэв

- Би тэгж найдъя, би итгэлтэй байна – гэж Нарцисс хэлээд – тэр нэг даваа гаригаас хойш би нэг сар ийм сайхан мэдээ сонссонгүй. Өнөө шөнө тайван унтана, маргааш өглөөнөөс зүрхэн дээр байсан бул чулуу алга болно гэдэгт итгэлтэй байна. Та нар надад бодох юм олныг өглөө. Гэвч бодохоо би маргааш өглөө болтол хойш тавъя. Би явж унтлаа, та нар ч гэсэн унтаж амарцгаана биз. Хөөе Ноб - гэж тэр үүд рүү явангаа дуудаад: - Ноб оо! Яст мэлхий минь ээ! гэж хашгирав.

- Ноб оо!- гэж тэр дахин дуудсанаа дух руугаа алгадаж: - Би сая юу мартчихав даа байз – гэж үглэв.

- Та бас нэг хүний захиаг явуулалгүй мартчихсан байх гэж би бодож байна – хэмээн Мерри түүнийг цаашлуулахад:

- Үгүй шүү, үгүй, ноён Брендизайк та надад тэр тухай бүү дурс! Харин та хариугүй санах гэж байхад минь дахиад мартуулчихлаа. Би одоо хаана байгаа билээ? Хөөе Ноб! Хожуул минь ээ! Өө нээрэн тийм л дээ, та нартай л хамаатай нэг юм ярих гээд мартчихсан байна. Яагаав нөгөө Цохиур Бургаас болоод адууны хулгайч нарын тухай юм. Тэрнээс та нарын худалдаж авсан нөгөө пони чинь одоо энд байгаа шүү. Хөөрхий өөрөө л хүрээд ирсэн шүү дээ. Тэр одоо надаас ч дээр байгаа шүү. Ирэхдээ хөгшин нохой шиг хэрзийсэн, сагсайсан юм ирсэн, гэхдээ удалгүй тэнхэрч сайхан болсон. Ноб тэрнийг олж ирсэн юм.

- Юу гэнээ? Миний Билл хүрээд ирсэн юм уу? Аавын минь хэлдгээр би азтай төрсөн хүн шүү. Бас нэг хүсэл минь биеллээ. Тэр одоо хаана байна? – гэж Сэм давхцуулан хэлэв. Тэр жүжээнд байгаа Биллийг эргэхээс нааш унтах янзгүй боллоо.

Аянчид Уулын сууринд маргааш нь өнжиж, ноён Нарциссын бизнес тэр өдөр жинхэнээрээ цэцэглэв. Түүний айдсыг хүмүүсийн анхаарал сарниаж, дэн буудал, уушийн газар нь зочдоор пиг дүүрэн байлаа. Эзнийг болон зочдыг нь хүндэтгэх үүднээс хоббитууд орой нь нийтийн танхимд оров. Зочдын асуулт төгсгөлгүй үргэлжилж, мань хоббитууд асуулт бүрд хариу өглөө. Уулын сууриныхан юм мартдаггүй бололтой, Фродог номоо бичиж байна уу, бичих үү? гэж олон хүн асуув.

- Одоохондоо үгүй, зөндөө их сэтгэгдэл байна, нутагтаа очоод тэмдэглэлүүдээ эмхэлж цэгцлэх бодолтой байна гэж Фродо булзааруулсхийн хариулж суув. Тэр бас Уулын сууринд болсон гайхамшигт үйл явдлуудыг номондоо заавал оруулна гэж амлаад, алс өмнөдийн чухал мөртөө уйтгартай олон үйл явдлууд номонд орох учраас Уулын суурины сонин сайхан үйл явдлууд номыг маань чимж өгнө гэж хэллээ.

Дараа нь нэг залуу Фродог дуу дуулж өгөөч гэж хүсэв. Гэвч цугларагсад түүний хүсэлтийг сонсонгуут дүнсгэр царайлсан учир тэр залуу хөвгүүн дахиж гуйсангүй. Нийтийн танхимд урьд нь болсон таагүй явдлыг дахин давтахыг хүмүүс хүсэхгүй байлаа.

Тэр өдөр болон шөнө аянчдыг Уулын сууринд байх хугацаанд тэндхийн амгалан тайван байдлыг алдагдуулсан ямар нэг түгшүүртэй явдал болсонгүй, гэвч маргааш өглөө нь аянчид эрт босов. Бороо шивэрсэн хэвээр, тэд харанхуй болохоос өмнө Хоббитани хүрэхийг зорьж байгаа, энэ бол их урт зам туулна гэсэн үг билээ. Уулын суурингийн ардууд бүгдээрээ тэднийг үдэхээр гадаа гарч ирсэн бөгөөд тэдний царай нэг жилийн өмнөх энэ өдөр тэднийг үдэж байсныг бодвол их л эелдэг, найрсаг байлаа. Аянчдыг өчигдөр орой ирэхэд нь хараагүй хүмүүс тэдний зэр зэвсэг, хуяг дуулгыг хараад алмайрч байлаа. Цагаан өмсгөлтэй, цагаан үс, сахалтай Гэндалфаас гэрэл цацарч байгаа мэт харагдана. Дөрвөн хоббитийн аль эрт мартагдсан баатруудын зэр зэвсэг, өмсгөлийг хараад биширч, түрүүнд нь баатар ван гэсэн үг сонсоод шоолон инээлдэж байсан хүмүүс хүртэл үнэхээр үнэний хувьтай юм байна гэж боджээ.

- За, замдаа сайн яваарай, гэртээ хариад аз жаргалтай сайхан амьдраарай – гэж ноён Нарцисс ерөөгөөд, - Хэрэв миний дуулсан сураг үнэн бол Хоббитанид бүх юм сайн сайхан биш байгаа шүү гэж би урьдчилан анхааруулах хэрэгтэй байх. Их л бэрх болсон гэгцгээж байна лээ. Бүх юм ар араасаа муудаад байгаа цаг болохоор миний санаа зовох юм ч их байна. Гэхдээ би тэсээд үлдэж чадвал та нар манай энд дахиад нэг хүрээд ирвэл бүх юм сайн сайхан болсон байхыг үзнээ. Та нар бүх асуудлаа удахгүй шийдвэрлэж чадна гэж би итгэж байна. Сайн яваарай, нэг хүрээд ирвэл би их баярлана шүү – гэлээ.

Аянчид түүнд сайн сууж байхын ерөөл тавиад Баруун хаалгаар гарч, Хоббитанийхаа зүг хөдлөв. Билл пони дахиад тэдэнтэй нийлж, энэ удаа ч гэсэн түрүүчийнхтэйгээ адил багагүй ачаатай болсон ч Сэмийн хажууд сэргэлэн цовоо ергүүлж байлаа.

- Өвгөн Нарцисс юунд санаа зовсон юм бол гэж би гайхаад байна – гэж Фродог хэлэхэд Сэм:

- Би юу болсныг мэдэж байна, заримыг нь харсан. Намайг Галадриэлийн толинд харахад моднуудыг хөрөөдөөд унагаачихсан, хөгшнийг байшингаас нь хөөгөөд гаргачихсан байсан. Би хурдан буцаж ирнэ гэж тэгэхэд өөртөө андгайлсан.

- Өмнөд тойрогт ч байдал базаахгүй байгаа нь илт байна. Энд тамхи ерөөсөө байхгүй байна шүү дээ – гэж Мерри хэлэв.

- Ямар ч байлаа гэсэн тариалан бүр байхгүй болсон юм байна, үүнд та нар эргэлзэх хэрэггүй – гэж Пин үг нэмэрлэв.

- Бүр байхгүй ч болчихоогүй, гэхдээ их доор орсон – гэж Гэндалф хэлээд – Та нар Саруманыг мартчихаагүй биз дээ. Тэр Мордороос ч өмнө Хоббитанийг сонирхож эхэлсэн юм.

- Зүгээр зүгээр, та бидэнтэй хамт явж байна, тэгэхлээр бид очоод тэр муу дайснуудаас газар нутгаа цэвэрлэж авна – гэж Мерри хэллээ.

- Би та нартай одоохондоо л хамт байна. Хоббитани руу явахгүй. Та нар өөрийнхөө ажил хэргийг өөрсдөө цэгцлэх ёстой. Тэгж чадах мэдлэг, туршлагатай болсон. Та нар ойлгохгүй байна гэж үү? Миний үе өнгөрч байна. Би одоо олон жил бурууг зөв болгож, мууг сайн болгохгүй, яаж хийхийг хүмүүст зааж өгч ч чадахгүй. Та нар одоо их өсч, хүч чадалтай болсон. Өсөх өсөхдөө бүр маш их өссөн, та нар агуу хүчтэнүүдийн энд хүрсэн. Би одоо та нарын төлөө санаа зовох шаардлагагүй боллоо. Тиймээс миний агуу андууд минь, та нар бусдаас тусламж гуйхааргүй боллоо. Ингээд би зам сална. Би Бомбадилтай нэг сайн ярилцах хэрэг байна. Амьдралынхаа туршид ярьж байгаагүй тийм чухал яриа байна. Тэр усан лянхуа түүгээд л жаргаж байдаг, би дэвэн дэлхийгээр хэсч явдаг. Гэхдээ миний хэсч тэнэдэг цаг дуусч байна, бид хэн хэндээ хэлэх юм ихтэй боллоо.

Төдөлгүй тэд Том Бомбадилаас салж явсан зүүн зам дээр хүрч ирэв. Хоббитууд Томыг хаа нэгтээгээс гараад ирэх болов уу хэмээн найдаж хэсэг зуур хүлээв. Гэвч тэр ойр хавьд байгаа шинж огт алга, алс өмнө зүгт Хөгшин ойн дээгүүр саарал манан хөвөрч харагдана.

Тэд зогссон хэвээр, Фродо өмнө зүг рүү горьдлого тээсэн нүдээр ширтэнэ.

- Хуучин андтайгаа уулзахсан гэж мөн ч их хүсч байна. Тэр одоо яаж амьдарч байгаа бол? – гэж тэр хэлэхэд Гэндалф:

- Яг л хуучин хэвээрээ гэдэгт итгэлтэй байж болно, хэрэв та нар хөгшин нарсанд айлчлаагүйсэн бол тэр юунд ч санаа зовохгүй, бидний үзэж туулсан, хийсэн зүйлүүдийн алийг нь ч сонирхохгүй. Хожим та нар тэднийд айчлах цаг ирж ч магад. Гэвч та нарын оронд би байсан бол одоо гэр рүүгээ яарах хэрэгтэй. Брэндуйний гүүрэнд хаалга хаагдахаас өмнө амжиж хүрэх хэрэгтэй.

- Гэвч тэнд хаалга байхгүй шүү дээ, зам дээр ч хаалга байхгүйг та сайн мэдэж байгаа шүү дээ. Хойт хаалга байдаг ч гэсэн тэр хаалгаар намайг хэзээ ч хамаагүй оруулна – гэж Мерри хэлэв.

- Тэнд хаалга байгаагүй нь үнэн, гэвч одоо байгааг та нар үзнэ. Хойт хаалганы тэнд ч чиний бодож байгаагаас хамаагүй түгшүүртэй байгаа. Гэвч та нар бүгдийг зохицуулж чадна. Баяртай эрхэм андууд минь, алгуурлалгүй давхиж үз, баяртай.

Тэр Аянгын жолоог их зам руу эргүүлэхэд агуу морин их зам дээгүүр саарал тоос татуулан умрын салхи мэт шуугиулан бараа тасарлаа.

- Бид анх дөрвүүлээ ирж байсан энэ зам дээр дахиад дөрвүүлээ хүрээд ирлээ. Бусдыг нь ардаа увуулж цувуулаад орхилоо. Надад яг л үргэлжилсэн зүүд шиг санагдаж байна – гэж Мерри хэлэв.

- Надад тийм биш байна, би дахиад л унтаж эхлэх шиг санагдлаа – гэж Фродо хэллээ.

Бүлэг 18

Хоббитанийн гуниг

Харанхуй болж байхад норж, ядарсан аянчид эцэст нь Брэндуиний гүүрэн дээр иртэл зам хаасан байхыг үзэв. Гүүрний хоёр үзүүрт асар том төмөр хаалга босгосон байх бөгөөд голын цаад талд шинээр хэдэн барилга барьжээ. Хоёр давхар, нэг эгнээ жижиг харанхуй цонхтой, хачин дүнсгэр, бараан барилгууд ажээ.

Тэд гадна хаалган дээр очоод чанга балбаж, хашгирсан боловч ямар ч хариу өгсөнгүй, тэгснээ хэн нэгэн бүрээ үлээж, цонхнуудад гэрэл асав. Харанхуй дотроос хэн нэгэн:

- Хэн бэ? Яв цаашаа! Орж болохгүй. Анхааруулах бичиг харахгүй байна уу? Орой нар жаргаснаас хойш өглөө нар гарах хүртэл орж болохгүй! – гэж зандрав.

- Харанхуйд тэр бичгийг чинь яаж харах юм бэ? Хэрэв Хоббитаний хоббитуудыг бороотой шөнө ингээд гадаа зогсоож байдаг юм бол би тэр бичгийг чинь олж, хуу татаж хаяна – гэж Сэм даналзав.

- Тэгтэл нэг цонх гэрэлтэж, зүүн талын байшингаас баахан хоббитууд бороохой барьсаар чихэлдэн гарч ирэв. Тэд дотор хаалгыг нээж, зарим нь гүүрэн дээгүүр наашлав. Тэд аянчдыг хараад айсан байртай бөөгнөрлөө.

Мерри тэдний нэгийг таниад:

- Чи намайг танихгүй байгаа юм бол наашаа ойртоод ир, Хоб Өвсөн-Овоохой би Мерри Брэндизайк байна, энд ер нь юу болоод байгааг би мэдмээр байна, чиний мэтийн хойт тойргийн хоббитууд яагаад энд байгааг ч мэдмээр байна. Чи өвсөн хаалган дээр л байх ёстой шүү дээ!

- Ээ бурхан минь, энэ чинь уран Мерри байна шүү дээ! Бас баатрын хувцас өмсч, зэвсэг агссан байна! – гэж өвгөн Хоб дуу алдаж: - Тэд яагаад таныг үхсэн, Хөгшин ой руу ороод алга болсон гэж хэлсэн юм бол? Таныг амьд мэнд хүрээд ирсэнд би баяртай байна.

- Тэгвэл яагаад төмөр сараалжны цаанаас над руу гөлрөөд байгаа юм бэ? Наад хаалгаа нээ!

- Өршөөгөөрэй ноён Мерри, гэвч бид хэнийг ч бүү оруул гэсэн тушаалтай.

- Юун тушаал вэ, бас?

- Том даргын тушаал

- Том дарга гэнэ ээ, тэр нь хэн юм бэ? Арай ноён Лото биш биз дээ? гэж Фродог асуухад,

- Магадгүй ээ, Ноён Баггинс. Тэгэхдээ бид одоо зөвхөн том дарга гэж хэлэх ёстой юм.

- Та нар ч хөөрхий амьгад юм даа, бид тэр том даргыг чинь нэг өдөр баяртайгаар аваад хаячихна. Гэр бүлийнхнийхээ өмнөөс тэрэнтэй тооцоо хийж, байх ёстой байран дээр нь суулгаад өгнө өө.

Хаалганы цаана байгаа хоббитууд их айж байгаа бололтой.

- Бид ингэж ярих юм бол их эвгүй юм болно – гэж тэдний нэг нь хэлээд: - Тэр сонсчихно. Та нар ийм чанга ярих юм бол Том даргын том хүнийг сэрээчихнэ шүү.

- Бид тэрнийг сэрээгээд хоёр нүдийг нь орой дээр нь гаргаад өгнө гайгүй. Та нарын тэр дарга чинь хүний үгийг хээрийн салхинаас сонсдог гэж бодож байгаа юм бол бид тийм ч хурдан буцахгүй шүү - гээд Мерри пони мориноосоо үсрэн бууж бамбарын гэрэлд харагдаж байсан анхааруулах бичгийг хуу татан авч хаалга давуулан шидэв. Тэгээд – Нааш ир Пин, хоёр хүн л хангалттай гэлээ.

Мерри, Пин хоёр хаалган дээр авирч гарахад цаана нь байсан хоббитууд зугтаав. Дахин бүрээ үлээх сонсогдоод, баруун талын арай том байшинд гэрэл асч, хагас нээлттэй хаалганы зурвас гэрэлд өндөр хүний дүрс харагдав. Тэр гарч ирснээ:

- Юу болоод байна? Хаалга эвдэж байна уу? Одоохон зайлцгаа, тэгэхгүй бол атганд багтах нарийхан хүзүүгий чинь хугалаад өгнө шүү! – гээд дөхөж ирснээ хуяг дуулга, илд хараад дороо нам зогсов.

- Өө! Цохиур бургаас шив дээ, чи арав тоолоход энэ хаалга онгойлгохгүй бол өөртөө гомдоорой! Би зовлогонд чинь ган илд хуйлаад өгнө! Хаалгаа нээгээд эндээс хэзээ ч эргэж ирэлгүй тонил! Адгийн хулгайч, замын дээрэмчин минь!

Цохиур бургаас хаалга руу ухасхийн ирж, хурдан нээв. “Түлхүүрээ нааш нь өг” гэж Мерри хэлэхэд урдаас нь шидчихээд харанхуй руу гүйж оров. Тэр пони морьдын хажуугаар өнгөрөхөд Билл пони тэрнийг нэг сайн тангарч унагаад, нүүр рүү нь байдгаараа тургиж орхив. Хулгайч мөлхөж холдонгуугаа босч, харанхуй руу алга болоод дахиж үзэгдэж сонсогдсонгүй.

- Сайхан болгоод өглөө дөө - гэж Сэм понигоо магтлаа.

- Танай том хүн их юм үзнэ ээ, харин том даргатай чинь бид дараа уулзана. Харин одоо бид энд шөнийг өнгөрөөнө. Өглөө биднийг сэрээгээрэй – гэж Мерри захирав.

- Өршөөгөөрэй ноён Мерри, гэвч ингэхийг зөвшөөрдөггүй юм.

- Юу зөвшөөрдөггүй гэж?

- Нормоос илүү идэж болохгүй гэх мэтээр олон зүйлийг зөвшөөрдөггүй.

- Яагаад тэр билээ? Ган гачиг болсон юм уу? Сайхан зун болж, их ургац авсан гэж би бодож байна шүү.

- Энэ жил сайхан зун болсон. Бид хангалттай их ургац авсан, харин хаашаа алга болсныг нь мэдэхгүй. “Хураалт”, “Түгээлт” гээд л зөндөө юм байдаг. Бидний бүх ургац, хүнсийг хураалтаар хураагаад авчихдаг юм. Би хураалтад дайчлагдаж, айлуудаар явж, хүнсийг тоолж, бүртгэж аваад агуулахад хүлээлгэж өгдөг. Тэд хураалт олон удаа хийсэн боловч түгээлт бараг хийгээгүй – гэж Хоб ярив.

- Нааш ирцгээ – гэж Пин эвшээгээд – Энэ шөнө би их ядарлаа. Бид хангалттай хоол авч яваа. Та нар хэвтээд өгөх өрөө гаргаж өг. Тэгвэл тэр чинь миний амьдралдаа үзсэн хамгийн тансаг сайхан өргөө болно.

Хаалганы дэргэд байгаа хоббитууд бас л айсан дүртэй хэвээрээ, харсаар байтал зарим дүрмийг нь зөрчихсэн. Гэвч бүгд зэвсэгтэй, эрэлхэг дайчин дөрвөн аянчинг хараад аргагүй эмээж байлаа. Ядаж хоёр нь том биетэй, булиа хүчирхэг харагдана. Фродо хаалгыг дахин түгжихийг тушаав. Хулгайч нар ойр хавьд байгаа учир ямар нэг хэмжээгээр харуул хамгаалалт гаргах хэрэгтэй байв. Дараа нь мань дөрвөн хоббит харуулын байранд орж боломжийн хэрээр тухлав. Тэр байр нь олигтойхон гал түлэх ч боломжгүй жижигхэн тулгатай, хоосон, уруу дорой царайтай жижиг өрөө байв. Эгнүүлж тавьсан хатуу модон ор шиг юмтай, дөрвөн ханаар нь дүүрэн элдэв янзын дүрэм журам, анхааруулга наасан байлаа. Пин шууд л орон дээр нь хэвтээд өгөв. Энд хоолны төрлийн юм юу ч байхгүй, пиво бол бүр ч ярилтгүй, аянчид үлдсэн хоол хүнсээ авчран харуулуудтай хуваалцаж, Пин босч ирээд дүрэм № 4-ийг зөрчиж маргааш түлэх нормын модыг нь бүгдийг түлж орхив.

- За яахав, Хоббитанид юу тохиолдсоныг бидэнд ярихгүй юм бол татах тамхи байна уу – гэж Пин асуув.

- Одоо энд тамхи тарихаа больсон. Зөвхөн том даргын татах тамхийг л бэлддэг. Байсан бүх нөөцийг хаа нэг тийш нь аваад явсан. Тэрэг тэрэг ачааг хуучин замаар өмнөд тойрог руу зөөсөн гэж би сонссон. Ноднин та нарыг явсны дараа шүү дээ. .. – гээд цааш ярих гэтэл:

- Амаа хамхи Хоб минь, ийм юм ярьж болохгүй гэдгийг чи мэдэж байгаа шүү дээ. Том даргын чихэнд хүрчих юм бол бид цөмөөрөө баларна шүү дээ – хэмээн бусад нь анхааруулав.

- Хэрэв бидний дунд том даргын чих байхгүй бол тэр бидний яриаг сонсохгүй шүү дээ – гэж Хоб халуухан хэлэв.

- Маш зөв, маш зөв. Хангалттай сайн хэлээ. Би үүнээс илүү үг сонсмооргүй байна. Хаа холын орнуудаар хэсэн бэдэрч, хатуу бэрхийг туулаад ирэхэл нутгийнхан маань баяртай угтахын оронд хаалгаараа ч оруулдаггүй, гүрүүшиг пиво ч байхгүй, татах тамхи ч байхгүй, харин баахан дүрэм, хориг. Шээж бааж ч болохгүй юм шиг байна. Би уг нь нутагтаа очоод амарч, алжаалаа тайлна гэж бодсон чинь бие сэтгэл зовоох юм бишгүй байх шиг байна. Одоо унтъя, өглөө болтол бүгдийг мартъя – гэж Сэм хэлэв.

Том дарга тэр дороо л мэдээлэл авчээ. Брэндуйний гүүрнээс Уутан хясаа хүртэл чилийсэн дөчин бээр боловч хэн нэгэн ховч нэн даруй даалгавраа биелүүлсэн бололтой. Ингээд Фродо ба түүний нөхөд тэр дороо илрэв.

Тэдэнд тодорхой төлөвлөгөө байгаагүй боловч юу ч гэсэн аятайхан газар жаахан амарья гэсэн бодолтой байлаа. Гэвч байдал нэгэнт бишэдсэн тул шууд Хоббитани руу явахаар шийдэв. Тэгээд маргааш өглөө нь шууд замдаа гарч, ширүүхэн ергүүллээ. Жихүүхэн салхитай, тэнгэр цэлмэг байв. Арван нэгдүгээр сарын эхэн, намрын сүүл сар болохоор газрын өнгө бүүдгэр бараан, нэг л гунигтай харагдана. Замын хоёр талаар энд тэндгүй бөөн хар утаа суунаглана. Бөглүү ойн зүгээс асар том хар үүл хөөрчээ.

Үдэш болоход тэд замын баруун талд, гүүрнээс хорин хоёр бээр зайтай оршдог Мэлхий сууринд дөхөж ирэв. Тэд тэнд хонохоор шийджээ. Учир нь суурингийн зүүн захад байдаг “Хөвөж буй гуалин” бол аятайхан амарч болох уушийн газар байв. Гэвч тэднийг суурингийн зүүн захад хүрч ирэхэд “Орж болохгүй” гэсэн бичигтэй асар том самбар босгож, тэрний цаана гартаа саваа барьж, малгайдаа өд хатгасан ширрифүүд бөөгнөрөн зогсч байлаа. Тэд айж байгаа нь илэрхий боловч их л чухал царайлах ажээ.

- Энд юу болоод байна? – гэж Фродо инэдээ барьж ядан асуухад:

- Ийм л юм болж байна, ноёнтон Баггинс – гэж тэдний ахлагч малгайдаа хоёр өд хатгасан ширриф хэлээд: - Та нар хаалга эвдсэн, дүрэм авч хаясан, хаалганы хамгаалагчдыг доромжилсон, хориотой хязгаар давсан, харуулын байранд унтсан, харуулуудад хоол, ундаар хахууль өгсөн хэргээр баривчлагдаж байна – гэв.

- Өөр юу гэмээр байна?

- Одоохондоо үүнээс өөр юм алга

- Хэрэв та нар иймэрхүү аястай байвал би юм нэмээд өгч чадна шүү!

Даргынхаа нэрийг хэл, би тэрний чинь тэнэг нүүрэн дундуур шавхуурдахыг хүсч байна, ширриф гэхээсээ хулигаанууд гэмээр амьтад минь – гэж Сэм томров.

- Ноёнтон гуай, энд дарга нь би байна. Одоо яах вэ гэдгийг сонсч бай: - Дарга та нарыг элдэв эсэргүүцэлгүй, томоотой яваад ир гэж тушаасан. Бид та нарыг дагуулан явж даргын төлөөлөгчид хүлээлгэж өгнө. Би та нарын оронд байсан бол энд удаан зогсох хэрэггүй, олон юм чалчихгүй байсан даа - гэж ширрифүүдийн ахлагч хэлэв.

Фродо болон түүний нөхөд элгээ хөштөл инээлдэхэд ширрифийн ахлагч тун эвгүй байдалд оров.

- Битгий дэмий юм яриад бай! Би энд хүссэн цагтаа хэрэгтэй газраараа явж байх болно. Би Уутан хясаа руу наймааны ажлаар явж байна, хэрэв та нар бидэнтэй хамт явах гээд байгаа юм бол дураараа л бол – гэж Фродо хэлэв.

Болж байна, - гээд ширрифийн ахлагч замын хаалтыг зайлуулаад: - Харин би та нарыг баривчилж байгаа гэдгийг битгий мартаарай – гэлээ.

- Би баривчлагдахгүй шүү, хэзээ ч үгүй. Харин та нарыг хэрэгсэхгүй байж болно. Би өнөөдөр

явахгүй, тиймээс та нар биднийг “Хөвж буй гуалинд”-д хүргэж өгөх юм бол би баярлаж талархаснаа илэрхийлнэ шүү - гэж Фродо хэлэв.

- Би тэгж чадахгүй ноён Баггинс, уушийн газар хаалттай байгаа. Суурингийн цаад захад одоо ширрифийн байр л байгаа. Би та нарыг тэнд л хүргэнэ дээ.

- Сайн байна, урд ороод явцгаа, бид та нарын араас явъя – гэж Фродо хэлэв.

Сэм ширрифүүдийг хөлөөс нь толгой хүртэл нэгд нэггүй харснаа нэгийг нь танив. Тэгээд “Хөөе чи нааш ир, Робин Жижиг Ухуур аа, хоёулаа хууч хөөрье” – гэж дуудав.

Нөгөөдөх нь ахлагч руугаа асуусан харцаар харахад цаадах нь дургүйцсэн шинжтэй байсан ч хориглоогүй учир ширриф Жижиг Ухуур Сэм рүү хүрч ирэхэд нь Сэм пони мориноосоо бууж, зэрэгцэн алхав.

- Хөөе, жоом Робин минь, чи Хоббитанид төрж өссөн, өөрөө мэдэж байгаа. Яагаад та нар ноён Фродо болон бидний замд тээглээд байгаа юм бэ? Уушийн газар яагаад хаагдсан юм бэ?

- Бүх юм хаагдсаан. Дарга пиво уудаггүй. Бараг тэгээд л хаасан биз. Даргын төлөөлөгч ирээд л бүгдийг хаасан. Тэр ардуудын дунд байж болохгүй, тэдэнтэй хамт явж болохгүй учир ямар нэг ажил хэрэг гарвал ширрифийн байранд ирж ажил хэргээ ярьдаг юм.

- Та нар юм бүгдийг ингэж ямар ч утгагүй болгож байгаадаа ичихгүй байна уу? Чи гэхэд л хээр хөдөө тэнэж явснаас уушийн мухлагт сууж байх дуртай байсан шүү дээ.

- Би одоо ч гэсэн тийм л баймаар байна. Тэгвэл надад сайхан байхсан. Би юу хийж чадах билээ дээ? Энэ бүхнийг эхлэхээс өмнө, долоон жилийн өмнөөс би ширриф болсон. Газар нутгаараа хэрэн хэсч, ардуудтай ярилцаж, шинэ мэдээ сонсч байдаг байсан, хаана сайн пиво байдгийг андалгүй мэддэг байлаа шүү дээ. Гэвч одоо өөр болсон.

- Гэвч та нар энэ бүхнийг зогсоож болно шүү дээ, хэрэв энэ ажил чинь хүндтэй ажил биш бол энд харуул хийхээ болих хэрэгтэй.

- Бидэнд тэгэхийг зөвшөөрөхгүй

- Зөвшөөрөхгүй гэсэн үг мөн ч олон удаа сонслоо, бүр уур хүрчихлээ

- Тэр чинь зөв л дөө. Хэрэв бид бүгдээрээ уурлах юм бол ямар нэг юм хийж чадах байх – гээд Робин дуугаа намсгаж - Гэвч эд бол даргын хүмүүс. Тэр энд тэндгүй өөрийнхөө хүмүүсийг тараачихсан. Хэрэв бидний цөөн хэдэн хүн эрхийнхээ төлөө босох юм бол тэд барьж аваад цоожтой нүхэнд хийчихнэ. Тэд хөгшин Тээрэмчин, хөгшин Уилл нарыг хамгийн түрүүнд барьсан, дараа нь олон хүн барьсан. Одоо байдал улам муудаж байна.

- Тэгвэл та нар яах гэж тэдний төлөө тэдний ажлыг хийж байгаа юм бэ? Та нарыг хэн энэ суурин руу явуулсан юм бэ? – гэж Сэм уурсав.

- Хэн ч явуулаагүй. Бид энд ширрифийн том байшинд суудаг. Одоо бид нэгдүгээр

зүүнтөйргийн цэрэг болсон. Энд хэдэн зуун ширриф байгаа, бүгдээрээ л шинэ журмыг хүсч байна. Олонхи нь өөрийнхөө үзэл санаатай зөрчилдөж байна, гэхдээ бүгдээрээ биш. Дарга болон түүний төлөөлөгчийн төлөө тагнуул хийдэг мэдээлэгчид ч байгаа.

- Аа тийм бий, тэгээд л бидний тухай тэрэнд хов хүргэж л дээ

- Яг тэгсэн. Тэд хуучин шуурхай шуудангийн үйлчилгээг ашиглаж байгаа, газар газарт тусгай хурдан морьд сойж байгаа. Өнгөрсөн шөнө Уитфорроос нэг буухиа мэдээч “Нууц мэдээ” авчирсан, эндээс бас нэг нь аваад явсан. Дараа нь тэндээс нууц мэдээ ирүүлсэн, тэр нь та нарыг баривчлах тушаал. Тэгэхдээ та нарыг шууд цоожтой нүх рүү явуулахгүй, ширрифийн байранд авчирч та нарыг харах гэсэн юм байх.

- Ноён Фродо тэрний ноёрхлыг эцэс болгоод өгөхөд тэр ингэж ихэрхэж чадахгүй байлгүй – гэж Сэм яриагаа дуусгав.

Мэлхий суурины захад байх ширрифийн байшин гүүрийн харуулын байрныхаас ч долоон дор тохигүй ажээ. Нэг давхар, бас л адилхан нарийхан цонхтой, маш муу цохисон үзэмжгүй муу хавтгай тоосгоор барьсан малын саравч шиг юм байв. Дотор талдаа ч ялгаагүй бүүдгэр, уруу дорой дүртэй, голд нь хоолны ширээ бололтой урт модон вандан байх бөгөөд тавцанг нь хэдэн сараар ч цэвэрлээгүй шинжтэй бохир харагдав. Хоол ундны төрлийн юм харагдсангүй. Аялагчид тэндээс хурдхан явахын түүс болж байв.

Туулагч Ус хүртэл арваннайман бээр зайтай, өглөөний арван цаг болж байв. Уг нь тэд их эрт гарсан боловч ширрифийн ахлагчийн дэмий ярианаас болж бага зэрэг цаг алджээ. Баруунаас хүйтэн салхи үлээж, дээрээс нь бороо шивэрч эхлэв.

Суурингаас хошин шогчдын цуваа гарч байгаа юм шиг байсан боловч суурингийн хэдэн хүн гадаа гарч тэднийг сонирхон ширтээхэд аянчид ямар ч гэсэн тэд өөрсдийг нь шоолон инээлдээгүй гэдэгт итгэлтэй байв. Хориод ширриф “Хоригдлууд”- ыг “тууж” явах гэсэн боловч Мерри тэднийг урдаа оруулан Фродо ба түүний нөхөд араас нь тууж явав. Мерри, Пин, Сэм гурав хошин яриа өрнүүлж, инээлдэж хөгжилдөн, дуулж явахад ширрифүүд хөөрхийлөлтэй харагдаж байгаа мөртөө чухал царайлж, харин Фродо таг дуугүй, бодолдоо автан уйтгартай явна.

Хамгийн сүүлд тэд хайсан дээрээ тохойлдон зогсч байгаа өвгөний хажуугаар өнгөрөхөд тэр “Хөөе, сайн уу, хэн нь хэнийгээ баривчилсан юм бэ?” гэж хөгжилтэй нь аргагүй хашгирав.

Хоёр ширриф тэр дороо цуваанаас гарч өвгөн рүү явлаа.

- Ахлагч аа, та тэр хоёрыг жагсаалд нь оруулахгүй бол би тэдний учрыг олно шүү! – гэж Мерри хэлэв.

Хоёр ширриф удирдагчийн эрс хатуу захирамжаар цуваандаа даруйхан эргэж орлоо. Нар хөөрч, жихүүн салхитай ч байсан ч гэсэн тэд дорхноо дулаацаж, бараг хөлрөх шахам явлаа.

Газрын гурван чулууны дэргэд ирээд тэд түр амрав. Тэгээд арван дөрвөн бээр орчим газрыг

ганцхан амраад тууллаа. Өдрийн гурван цаг болж байлаа. Ширрифүүд хоол ундаар дутмаг учир дорхноо ядарч, хөл дээрээ арай ядан тогтож байв.

- За яахав, та нар өөрсдийнхөө тааваар явцгаа, бид яарч байна – гэж Мерри тэдэнд хэлэв.

- Баяртай Жоом Робин. Хэрэв чи “Ногоон луу” уушийн мухлагийг мартчихаагүй бол би тэрний гадаа чамайг хүлээж байя, зам дээр битгий ойчоод өгөөрэй дээ – гэж Сэм хэлэв.

- Та нар баривчилгааны дүрмийг зөрчиж байна, би үүнийг чинь хариуцахгүй шүү - гэж ахлагч зандрах маягтай хэлэхэд Пин:

- Бид одоо олон дүрэм зөрчинө, тэгэхдээ та нарыг хариуцлагад унагахгүй, сайн сайхныг ерөөе – гэлээ.

Аянчид хагируулан одоход нар тэнгэрийн баруун хаяан дахь Цагаан тал руу хэвийж, тэд энэ урт аянд гарснаас хойш анх удаа сэтгэл нь хөөрөн догдлов. Энэ газар бол Фродо, Сэм хоёрын төрсөн нутаг бөгөөд тэр хоёр энэ газрыг ертөнцийн ямар ч газар орноос илүүгээр хайрладаг билээ. Тэр хоёрын мэддэг таньдаг олон айлын байшин алга болжээ. Заримыг нь шатаасан ор мөр харагдаж байна. Цөөрмийн хойт эргийн дагуу эгнэн нүд баясгадаг байсан хоббитуудын оромжууд оргүй алга болж, тэдний жижигхэн цэцэрлэгүүд зэрлэг ургамлаар дүүрчээ. Хамгийн муухай нь голын эрэг, цөөрмийн эргэн тойронд дотор нь юу байгаа нь үл мэдэгдэх хачин муухай барилгууд шинээр барьсан байв. Тийм барилгууд замын дагуу шавааралдан үргэлжилжээ. Уутан хясааны наахна юу нь үл мэдэгдэх тоосгон барилга харагдав. Тэр барилгаас үдшийн тэнгэрт хар утаа олгойдож байна.

Сэм тэрнийг хараад байж ядан бачимдав.

- Ноён Фродо зөвшөөрнө үү, би түрүүлж явъя! Миний Жихарь ямаршуу байна мэдээдэхье – гэж тэр хашгирав.

- Бүү яар, биднийг Голын хөндийд бүлэг дээрэмчдэд гардуулчих дөхсөн шүү дээ. Эхлээд энэ хавиас хэн нэгэнтэй уулзаж, чухам юу болоод байгааг мэдэх хэрэгтэй – гэж Фродо хэлэв.

Гэвч асуух хүн байсангүй. Тэднийг харанхуй цонх, хаалттай хаалганууд угтлаа. Тун хачирхалтай санагдсан боловч удалгүй учир нь олдлоо. Норгордын хамгийн захын байшин “Ногоон луу” бүр хоосрон хаягдаж, хэдэн цонх нь хагарсан байх бөгөөд тэнд хамгаалагчид хүлээж байлаа. Сөлөр нүдтэй, шар царайтай зургаан чийрэг эр мухлагийн хана налан зогсоно.

- Бүгдээрээ л Уулын сууринд байсан нөгөө Цохиур бургаас шиг юмнууд байна даа – гэж Сэм хэлэв.

- Би ийм юмнуудыг Изенгардад бишгүйдээ л нэг харсан - гэж Мерри бувгнав.

Харуулууд гартаа бороохой барьсан байх бөгөөд бүгдээрээ бүсэндээ бүрээ зүүснийг эс тооцвол өөр зэвсэг байхгүй бололтой. Тэд хананаас дуртай дургүй хөндийрч, хоббитуудын

замыг хаав.

- Та нар хаашаа ингэтлээ яараа вэ? Буугаад ир, та нарыг харгалзаж ирсэн эрхэм ширрифүүд хаачсан бэ?

- Тэд яаралгүй ирж яваа. Хөөрхөн хөлнүүд нь ядарчихсан. Бид тэднийг энд хүлээнэ гэж амласан юм л даа - гэж Мерри хэлэв.

- Бөөсөнд хутга гаргана гэгч болох нь шив, би юу гэж хэллээ дээ? - хэмээн тэдэн дотроо арай бадриун, өндөр нь нөгөөдүүлдээ хандаж хэлээд:

- Шаркичад би хэлсэн шүү дээ. Муу бөөснүүдийг шууд барь гэж. Манай залуус эднийг аль хэдийнэ чирээд ирэх байсан юм.

- Чирээд ирэх байсан гэж үү? Юу л бол. Урьд нь манай нутгаар ийм сүгнүүд үзэгддэггүй л байсан юмсан. Харин одоо та нарыг манайд тавтай зочлуулахгүй байх шүү - гэж Мерри хэлэв..

- Чи юу гэнэ ээ, сүг гэсэн үү! Овоо муу гар уу, үгүй юу! Их хуцаж байна аа, гайгүй ээ чи, одоохон гасална. Бөөс хүртэл бүдүүн дуугардаг болжээ. Та нар удирдагчийг сайхан сэтгэл гаргана гэж найдсаны хэрэггүй. Шаркич албан тушаал дээрээ байгаа, удирдагч Шаркич юу хэлнэ, тэрийг л хийнэ.

- Тэр юу гэж хэлэх юм бэ? - гэж Фродо тайван асуув.

- Та нар шиг юмнууд өөрийгөө таньдаг байхын тулд дэг журам тогтоо гэж хэлнэ. Шаркич дэг журам тогтоож чаддаг юм. Их дургүйг нь хүргэвэл их цус асгаруулж тогтооно. Та нарт өөр удирдагч хэрэгтэй, тэр хүрээд ирнэ, бүр шинэ он гарахаас өмнө. Тэр үед муу хулганууд та нар бидний өмнө бүжиглэх болно оо.

- Та нарын яриаг сонсох их сонихролтой байлаа. Би яг одоо ноён Лоттод бараалхах гэж байгаа юм, тэрэнд ч гэсэн сонирхолтой байх байлгүй – гэж Фродо эелдгээр өгүүлэв.

Харуул тачигнатал инээв.

- Лотто гэв үү? Тэр тэртэй тэргүй мэдэж байгаа, бүү санаа зов. Тэр Шаркичийн хэлсэн бүхнийг биелүүлнэ. Тэгэхгүй бол тэрнийг одоохон зайлуулна. Ойлгов уу чи? Харин тарган бөөс чи тэрнийг хамгаалах гэвэл та нарыг бид газарт булчихна шүү. Ойлгов уу?

- Ойлголоо. Юуны өмнө та нар зах хязгаар газар байгаа болохоор сураг ажиг сонсдоггүй юм байна гэж ойлголоо. Чи өмнөдөөс ирсэн үү? Тэгвэл одоо өмнөдөд бүх юм өөр болсон. Чам мэтийн дээрэмчдийг өнөө маргаашгүй устгана. Хар цамхаг байхгүй болсон, Гондорт их хаан заларсан, одоо танай эзэн чинь ердөө л хөөрхий муу гуйлгачин болсон. Бидний замд тэнэж явна лээ. Изенгардын дээрэмчдийг бутниргэсэн, одоо чиний мэддэг далд замаар хааны элч нар давхиж ирнэ – гэж Фродо тайван хэлэв.

Харуул түүнийг хөлөөс нь толгой хүртэл сонжин хараад дарвайтал инээв.

- Хөөрхий муу гуйлгачин! – хэмээн элэглэсэнээ:

- Хуцаад бай, сүүлийг чинь тастах хүртэл хуцаад бай, бөөс минь. Одоо бид та нарыг сайхан мулзлаад өгнө, голийтлоо таргалчихаж хөөе! Чиний хааны элч нар руу би нулимна – гээд Фродогийн нүүрэнд тулган хуруугаа инчдэсэнээ:

- Юуны чинь элч нар? Нэгийг нь харж байж л больё - гэв.

Тэгтэл Пиний тэвчээр алдрав. Тэр Кормаллены талыг санав. Тэр агуу үйл явдлын дараа ямар нэг муу хялар новш бөгж хадгалагчийг бөөс гэж хэлнэ гэнэ ээ? Тэр нөмрөгөө ярж, илдээ сугалахад Гондорын гол хэрмийн хамгаалагчийн мөнгөлөг хар хуяг бүдэгхэн гялсхийв.

- Би хааны элч байна! Чиний өмнө их хааны анд нөхөр, өрнөдийн цэргийн баатар ван зогсч байна. Харин чи бол чалчаа новш, хогийн шаар. Өвдөг сөгдөөд өршөөл гуй, тэгэхгүй бол надад алуулсан троллын араас орно шүү!

Жаргах нарны туяанд илдний ир гялсхийв. Мерри, Сэм хоёр ч илдээ сугалан дөхөж ирэв. Фродо байрнаасаа ч хөдөлсөнгүй. Харуулууд арагшаа ухарлаа. Тэд энгийн номхон уулын сууриныхан болон гэнэн цайлган хоббитуудыг айлгаж сүрдүүлээд сурчихсан бөгөөд ширүүн зантай, айхыг үл мэдэгч, илд гялалзуулсан дайчдыг огт хараагүй ажээ. Тэгээд ч тэдний яриа эндхийнхнээс огт өөр байлаа. Нэг үгээр хэлэхэд айхаас өөр арга тэдэнд байсангүй.

- Эндээс тонилцгоо! Дахиад энд үзэгдэх юм бол сайхан мэдээрэй... - гэж Мерри зандрав.

Гурван хоббит мориндоо мордож хөдлөхөд харуулууд Норгордын замаар ум хумгүй зугтах зуураа бүснээсээ бүрээгээ аван үлээж байлаа.

- Ярих юм алга, цагаа олж ирлээ - гэж Мерри хэлэв.

- Хэрэв хожимдоогүй бол шүү дээ. Хожимдсон ч байж магадгүй. Тэнэг Лоттог аварч чадахгүй бол - гэж Фродо хэлэв.

- Юуны чинь Лоттог аврах. Өөрийн ухаантай байна уу, чи? Тэгснээс Лоттог зүйл дуусга гэж хэлсэн нь дээргүй юу?

- Пин чи өнөөгийн ажил хэргийг ойлгохгүй байх шиг байна, Лотто бол энэ балай юмны буруутан төдийгүй эхлэгч нь. Тэр мэдээж тэнэг амьтан, бүр өөдгүй муу тэнэг, энэнд л тэрний гай байгаа юм. Гэтэл тэрний гар хөл бологсод нь тэрнээсээ дээш гарчихаж. Тэд тэрний нэрийг бариад хурааж, дээрэмдэж, дураараа загнаж байна. Тэр бол Уутан хясаанд хоригдсон хоригдол. Одоо үхтлээ айчихсан байгаа биз. Тэрнийг тэндээс нь гаргачихвал сайн юмсан – гэж Фродо хэлэв.

- Гайгүй ч байна даа! Лоттог чөлөөлөх гэж есөн жорын муусайн юмнуудтай байлдах гэж үү!

- Байлдах ий? Гэхдээ байлдахаас зайлах аргагүй байх аа. Байлдлаа ч гэсэн нөгөө том даргын талд байлаа ч гэсэн хоббитуудыг алж болохгүй. Хоббитууд хэзээ ч нэг нэгнийгээ алж байгаагүй. Бид тийм заншил тогтоож болохгүй. Ер нь хэнийг ч алахгүй байвал сайн, тэсэхийг

хичээгээрэй!

- Энэ ч яамай байна аа, байлдахдаа хүрвэл хүссэн ч, хүсээгүй ч алахаас өөр зам байхгүй болно. Миний эрхэм найз Фродо, чи уучлаарай. Хоббитаниг ч аахилж уухилаад аварч чадахгүй гэдгийг ойлгоорой.

- За энэ ч яамай, харин дараа нь хэцүү болох вий. Сая ч яахав, бид үлээгээд л хөөчихлөө. Тэд зүгээр ч нэг бүрээдээгүй. Өөрийнхнийгөө дуудсан биз. Хорин дэрэмчин ирэхэд л тэд зориг орно. Тэсэх л болж дээ! Одоо бид нэг аюулгүй газар олж хонох хэрэгтэй. Зэвсэгтэй ч гэсэн бид дөрвүүлхнээ шүү дээ – гэж Пин хэлэв.

- Ерөөсөө ингэе, өмнөд булан орж, хөгшин Том Кроттон руу очъё! Тэр хулчгар хүн биш, хөвгүүд нь ч чанга залуус байгаа, дашрамд хэлэхэд бүгдээрээ миний найз – гэж Сэм хэлэв.

- Үгүй ээ! - хэмээн Мерри толгой сэгсэрч:

- Нуугдаж хонохоос татгалзаж байна. Бүгдээрээ л нуугдаад байгаа юм шиг мөртөө зүгээр л юу ч хийлгүй суух гээд байгаа нь илт байна. Ингэх дээрэмчдэд ашигтай. Тэд бөөнөөрөө ирээд биднийг бүсэлж аваад өлсгөж унагах юм уу, галдаж орхино. Нэн даруй хөдлөх хэрэгтэй байна.

- Нэн даруй гэдэг зөв, гэхдээ яаж? – гэж Пин асуув.

- Бослого гаргах хэрэгтэй! Хоббитанийг нэлэнхүйд нь босгох хэрэгтэй! Энэ шинэ журам гэгч нь хоёр гуравхан бузар новш, бас хойшдоо юу ч болсон хамаагүй – зөвхөн шинэ эздийн улыг долоож, ашиг завшаан хайж байгаа хорь гучин өөдгүй амьтдаас бусад бүгдийн тэвчээрийг барж байгаа. Хоббитууд хэтэрхий амгалан зантай, тааваараа жаргаж дассан учраас яахаа мэдэхгүй байна. Нэг л оч үсэргэвэл дүрхийгээд л асна. Үүнийг нөгөө том даргынхан арьсаараа мэдэрч байгаа. Хөл дорх газраа цөмлүүлэхгүйн тулд тэд биднийг хоромхон зуурт зүйл дуусгахыг бодно. Тиймээс бидэнд цаг маш бага байна. Сэм, чи Кроттоны эдлэн рүү давхи. Тэр их юм үзсэн толгой, бүгдээрээ түүнийг хүндэтгэдэг. Түргэлж үз! Харин би одоо ристанийн бүрээгээ үлээгээдхэе, эндхийнхэн тийм хөгжим насаараа сонсоогүй биз!

Тэд суурингийн төв талбайд ирж, Сэм өмнө зүг эргэн Кроттоныхон руу давхилаа. Гэнэт үдшийн нам гүмийг цочоон эвэр бүрээ цууриатав. Бүрэн дуу эргэн тойрны уул талыг доргион хүнгэнэхэд Сэм арай л буцаад давхичихсангүй. Пони нь хойт хөл дээрээ цоройн янцгаав.

- Зүгээр, зүгээр Билл, одоохон буцаад давхина! - гэж Сэм морио тайвшруулав. Мерри тэр хооронд Забрэндин хуучны түгшүүрийн дохиог бүрээдэв:

БОСООРОЙ! БОСООРОЙ! ДАЙСАН ДОВТОЛЛОО!

ТҮЙМЭР! ДАЙСАН!

ТҮЙМЭР! ДАЙСАН! БОСООРОЙ! БОСООРОЙ!

Эргэн тойронд хүмүүс шуугилдан, хаалга тас няс хийхийг Сэм сонсов. Цонхнууд гэрэлтэн, ноход хуцалдаж, морин төвөргөөн тачигнав. Тэр гудамж тойрохдоо Кроттон болон түүний гурван хүү Том, Жолл, Ник нарыг дайрчих шахав. Тэд гартаа сүх барьчихсан гүйж явснаа Сэмийн урьд хана мэт эгнэн зогсов.

- Хүүхдүүд минь, тэдний нэг биш ээ! Нуруугаар хоббит мөн шиг байна, хувцас нь эндхийнх биш. Хөөе! Чи хэн бэ, яагаад шуугиан дэгдээв? – гэж Кроттон асуув.

- Би Сэм, Сэм Скромби байна. Би эргээд ирлээ!

Өвгөн Том Кроттон дөхөж ирээд сайн харснаа:

- Хөөш! Дуу нь хэвээрээ, нүүр царай нь ч хэвээрээ. Сэм дүрээрээ байна. Гэхдээ л танигдахааргүй болжээ. Харь газраас ирсэн нь илт. Чамайг чинь талийгаач болсон гэцгээгээд байсан шүү дээ.

- Тэр худлаа! Би ч амьд мэнд, ноён Фродо ч гэсэн. Тэр энд ойрхон байгаа. Тэр л хоёр найзтайгаа шуугиан дэгдээсэн юм. Бид дээрэмчидтэй, бас тэр том даргатай тооцоо бодох гэж байна. Юу ч гэсэн эхэлчихлээ, юу болохыг үзэцгээнэ дээ.

- Сайхан юм болно! – Ашгүй нэг юм эхэлж дээ! Миний гар бүр эртнээс загатнаад байсан юм. Даан ч манай гэрийнхэн цөөдөөд байгаа юм. Эхнэр маань, бас Роза минь л байна. Энэ новшнуудаас болж эмэгтэйчүүдээ зовоох нь. За за хүүхдүүд минь гүйгээрэй, Голын хөндийгөөс эхэлнэ! Бид хоцрохгүй ээ!

- Хатагтай Кроттон, Роза хоёрыг яах вэ? Тэр хоёрыг үлдээж болохгүй.

- Тэр хоёртой Нибс үлдсэн. Чамд цаг байгаа юм бол очиж түүнд туслахгүй юу - гээд Кроттон мушилзсанаа хөвгүүдийнхээ хойноос харайлгав.

Сэм тэднийх рүү яарлаа. Уудам хашаан дахь байшингийнхаа үүдэнд хатагтай Кроттон, Роза хоёр зогсч, наана нь Нибс том сэрээ барьчихсан байлдаанд бэлэн байгаа харагдав.

- Битгий ай, би байна, Сэм Скромби! Намайг битгий сэрээдчихээрэй, Нибс, тэртэй тэргүй нэвтрэхгүй, би хуягтай!

Тэр мориноосоо үсрэн буугаад байшин руу гүйхэд тэд ихэд гайхан харж байв.

- Сайн байна уу, хатагтай Кроттон! Сайн уу, Роза!

- Сайн ууь Сэм! - хэмээн Роза хариу мэндлээд:

- Чи хаашаа алга болчихов оо? Чамайг үхсэн гэцгээгээд л байсан, гэсэн ч би хавраас хойш чамайг хүлээсэн. Чи яарч яваа юм уу?

- Үнэнээ хэлэхэд би маш их яарч явна. Бид энэ дээрэмчидтэй нэгийгээ үзэлцэх гэж байна. Би одоо ноён Фродо руу очно. Танайхаар буугаад мордьё, та хоёрыг ямаршуу байна, харъя гэж л

бодоод ирлээ.

- Юун сайн юм бэ, бид яахав, амьдардгаараа л амьдарч байна. Харин хаанаас ч гараад ирсэн юм, хэн ч юм бүү мэд, амар тайван амьдруулахгүй юм байна – гэж хатагтай Кроттон хэлэв.

- Чи явах гэж байгаа газар руугаа яв! Ноён Фродо, ноён Фродо л гэнэ, дөнгөж харагдчихаад л зугтааж байгаа юм биз дээ? – гэж Роза гомдоллов.

Энэ тухайд нэг бол бүтэн долоо хоног тайлбарлах, нэг бол дуугүй байсан нь дээр тул Сэм шууд эргэж мориндоо мордов. Роза араас нь гүйж ирээд:

- Сэм, чи ямар гоё болчихоо вэ! За яв яв, би зүгээр л. Биеэ хайрлаарай даа. Тэр дээрэмчдээ янзалчихаад л хурдан хүрээд ирээрэй!

Сэмийг талбай дээр ирэхэд сууриныхан бүгдээрээ бужигнаж байлаа. Залуучууд хамгийн түрүүнд ирж, дээр нь сүх, алх, урт хутга, мунаар зэвсэглэсэн зуу гаруй чийрэг хоббитууд цугларчээ. Зарим нь нум сумаа агсчээ. Тэр ч байтугай ойролцоох сууриныхан ч ирж байв.

Хэн нэг нь томоо гэгч түүдэг гал асаажээ. Том дарга гал асаахыг хатуу хориглосон тул зориуд ингэсэн ажээ. Түүдэг гал улам дүрэлзэн аслаа. Меррийн тушаалаар сууринг хоёр талаас нь бүслэн хаав. Зүүн талаас хаасангүй. Тэндээс нөгөө хоцорсон ширрифүүд ирээд юу болж байгааг гайхан харснаа малгай дээрх өдөө сэмхэн авч хаяад хүмүүсийн дунд оров. Гэвч нэг нь даргадаа мэдээлэхээр гүйжээ.

Фродо, Пин, Мерри нар Том Кроттонтой ярилцаж, баярлаж хөөрсөн олон тэднийг бүчин тойрсон байв.

- Одоо яах вэ? - гэж Кроттон асуув.

- Мэдэхгүй байна аа, хамгаалагчид хэр олуулаа вэ? – гэж Фродо эргүүлэн асуулаа.

- Чөтгөр л мэдэх байх, ирж хэсэг бусниулчихаад л яваад өгдөг юм. Тавь орчим болов уу. Норгордын хуаранд л байдаг юм. Дуртай цагтаа ирж, дээрэмдэж байгаад явчихдаг. Даргынх нь дэргэд яг хорин хүн байгаа. Тэр Уутан хясаанд байсан... өөр газар ч байж магадгүй. Энд л лав ирээгүй. Бараг долоо хоног тэрнийг хэн ч хараагүй, тийшээ орох аргагүй юм чинь.

- Норгордодод бүгээдээрээ цугларсан юм болов уу? – гэж Пин асуув.

- Тэнд цуглараагүй. Урт сүүл, Сарны гарам, Ойн буланд олуулаа цуглардаг гэсэн. Гол уулзварт тэдний хуаран байдаг. Ер нь Хоббитани даяар гурван зуугаад юм байгаа байх. Тэрнээс илүүгүй. Бид дийлнэ ээ.

- Ямар зэвсэгтэй бол? – гэж Мерри асуув.

- Байгаагаараа л зэвсэглэсэн. Ташуур, хутга, бороохой бүгдэд нь байгаа, өөр зэвсэг харагдаагүй. Жинхэнэ байлдаан болвол өөр юм гаргаж ирэх байх, лав л нум сум байж таарна. Манай хоёр ч хүнийг харвасан.

- Сонсоо биз, Фродо? Зодоон зайлшгүй гэж би хэлсэн шүү дээ. Тэд манай хүмүүсийг хөнөөснөөрөө дайн эхэлсэн гэсэн үг – гэж Мерри хэлэв.

- Тэд ч яг эхлээгүй юм аа, бид эхэлж харвасан юм. Молтогчингууд шүү дээ. Танай эцэг ноён Перегрин тэр Лоттог үзэж чаддаггүй юм. Тэр Лоттод яагаад ч юм хэн нэгэнд ямар нэгэн удирдагч хэрэгтэй юм бол манайд хууль ёсны хоббит удирдагч байгаа гээд хэлчихсэн юм. Лотто том дарга нараа явуулж, ноён Перегринийг номхруулах гэсэн боловч бүтээгүй. Тэгээд түүнийг болон бүх молтогчингуудыг Ногоон толгойн тэнд байдаг том том нүхнүүдэд орж суу, хамраа ч цухуйлгаж болохгүй гэж тушаасан юм. Хариуд нь молтогчингууд гурван дээрэмчинг харваад алчихсан юм. Тэгээд л нөгөө засан хүмүүжүүлэх нүхнүүдэд орчихсон хэрэг – гэж өвгөн Кроттон тайлбарлав.

- Молтогчингууд ч мөн дөө! Одоо тэр нүхнүүд рүү явах болж дээ, би тэр нүхнүүдийг арван хуруу шигээ мэднэ. Хэн надтай хамт явах вэ? – гэж Пин хэлэв.

Тэр хориод анчдыг сонгож аваад мориндоо мордлоо.

Удахгүй хүрээд ирнэ. Тариан талбайгаар арван дөрвөн бээр л явдаг юм. Өглөө гэхэд молтогчингуудын хороог аваад ирнэ!- гэж тэр хэллээ.

Тэд бүрэнхийд уусан далд ороход хурсан олон араас нь баяртай хашгиралдаж, Мерри бүрээгээ хүнгэнүүлэв.

- Гэлээ ч гэсэн нэг ч хүн алахгүй байвал сайнсан, харуулуудыг ч гэсэн. Бүр өөр аргагүй болвол одоо яая гэхэв - гэж Фродо хэлэв.

- Аргагүйдэхгүй өөр яав л гэж. Тэд одоо Норгордоос бидэн рүү ирж яваа биз. Хэлэлцээ хийх гэж ирэхгүй байх гэж айж байна. Эхлээд эв зүйгээр ярилцахыг хичээе, гэхдээ хамгийн муу юм болоход бэлэн байх хэрэгтэй. Надад нэг төлөвлөгөө байна – гэж Мерри хариуллаа.

- За тэгвэл чи захир- гэж Фродо зөвшөөрөв.

Норгордын зам дээр харуулд гарсан хоёр хоббит гүйж ирлээ.

- Ирж явна! Хорь гаруй хүн байна. Хоёр нь баруун тийшээ гүйчихлээ.

- Уулзвар руу явж байгаа нь тэр. Нэмэлт хүч авчрах нь л дээ. Тийшээ элбэгхэн арван таван бээр явна, эргээд ч бас. Одоохондоо хүлээзнэе – гэж Кроттон өгүүлэв.

Мерри тушаал өгөхөөр явж, фермер эмэгтэйчүүд, хүүхэд багачуудыг гэр гэр рүү нь явуулаад, зэвсэглэсэн эрчүүд хашаа хорооны цаагуур нуугдав. Гудамж, талбайд хэн ч байхгүй болмогц чангаар ярилцах, пир пархийтэл алхах чимээ гарч, харуулууд бөөнөөрөө гарч ирээд, хоббитуудын санд мэнд тавьсан гудамжны хаалтыг харангуутаа ха ха ха хөхрөлддөв. Тэд хориулаа энэ жижигхэн, намуухан сууринд эзэн нь юм шиг аяглаж байлаа.

Хоббитууд замын хаалтаа авч, арагш ухарлаа.

Тэгж л таарна даа! Ороолгуулаагүй дээрээ хурдхан ор орондоо орцгоо – хэмээн тэд дээрэлхэв.

Тэд гудамжаар явж:

- Бүгд гэрлээ унтраа! Хэн ч гадагшаа гарч болохгүй. Тушаал биелүүлэхгүй бол тавин хоббитыг барьцаанд авч засан хүмүүжүүлэх нүхэнд хорино. Хурдал, хурдал! Тоглож дууслаа, их удирдагчийн тэвчээрийг барж байна шүү, та нар! – гэж хашгиралдана.

Гэвч тэдний хашгирааныг хэн ч тоосонгүй, харин ч араас нь бөөнөөрөө чимээгүй дагацгаав. Талбай дээр ганцхан Кроттон үлдээд түүдэг галд гараа ээж суув.

- Чи хэн гэгч вэ? Энд ямар үлийгээ хийж байгаа юм бэ? – гэж дээрэмчдийн толгойлогч гуаглах мэт хашгирав.

Кроттон аажуухан босч, түүн рүү хараад:

- Харин би наад асуултыг чинь та нарт тавимаар байна шүү. Та нар юугаа хийх гэж бусдын газар нутагт дайрч орсон юм бэ? Та нарыг хэн ч уриагүй.

- За тэгвэл бид чамайг урина аа! гэж толгойлогч зэвүүнээр инээгээд:

- Барь наадахыгаа! Засангийн нүхэнд чирж аваачаад хийчих, замдаа эелдэг харьцаанд сургаад өг!

Фермер руу хоёр нь ухасхийсэн боловч бүдрэх мэт зэрэг уналаа. Эргэн тойронд хоббитууд шуугилдаад явчихлаа. Кроттон ганцаараа байгаагүй ажээ. Хоббитууд галын гэрэлд орж ирэлгүй харанхуйд тойрон зогсчээ. Тэд хоёр зуу гаруй, бүгдээрээ зэвсэгтэй.

Мерри урагш давшин гарч ирэв:

- Бид өнөөдөр чамтай тааралдсан шүү дээ. Тэгээд та нарт дахиад наашаа хамраа битгий цухуйлга гэж анхааруулсан. Сонсоогүй юм уу? Тэгвэл одоо сонс. Та нарыг харваачид онилчихсон байгаа. Нэг л хүнд гар хүрэх юм бол та нар эндээ зүйл дуусна шүү. Бүгд зэвсгээ хаяцгаа!

Толгойлогч эргэн тойрноо хараад бүслэгдсэнээ ухаарав. Гэвч хулчийсангүй. Хорин өндөр чийрэг залуу түүнтэй хамт байгаад бардсан бололтой. Тиймээс эргээд Норгорд руу саадгүй яваад орчихно гэж боджээ.

- Эднийг балбаад өг, алаад өг! гэж тэр хашгирав

Тэгээд зүүн гартаа урт хутга, баруун гартаа бороохой бариад, замыг нь хааж зогссон Мерри рүү дайрав. Түүнийг алчих юм бол бусад нь амархан гэж боджээ. Гэвч дөрвөн талаасаа суманд сүлбүүлэн унав. Энэ л хангалттай байсан тул бусад нь зэвсгээ хаян гар өргөлөө. Тэднийг хүлж, нэгэн цагт өөрсдийнх нь барьсан хоосон саравчинд хориод манаа тавив. Толгойлогчийнх нь хүүрийг хог хаядаг газарт чирж аваачаад булж орхив.

- Нэг, хоёр гээд л болох шив дээ, аан? Бид тэднийг амархан дийлнэ гэж би хэлээ биз дээ. Зөвхөн эхлэх, дуусгах л хэрэгтэй байсан юм. Та цагаа олж ирлээ, ноён Мерри – гэж Кроттон өгүүлэв.

- Эхлэхийг ч эхэлчихлээ, харин дуусгах хаа ч байсан юм. Хэрэв тэд гурван зуу орчим гэдэг үнэн бол бид аравны нэгийг нь ч жагсаалаас гаргаагүй байна. Гэхдээ одоо харанхуй боллоо. Өглөө болтол хүлээе. Өглөө энэ гийчдийг дайлаад, дараа нь Том даргад нь бараалхаж.

- Яагаад одоо биш гэж? Тийм ч оройтоогүй, дөнгөж зургаа болж байна! Би Жихартайгаа уулзахсан гэхээс тэсч ядаж байна - гэж Сэм хэлээд:

- Ноён Кроттон, эцэг маань ямаршуухан амьдарч байгааг мэдэхгүй биз?

- Мэдэлгүй яахав, тийм ч муу биш, Сэм. Гэхдээ цэцэрлэгийг нь ухаад хаячихсан, мэдээж өвгөний сэтгэл их хямарсан. Одоо шинэ байранд сууж байгаа. Дарга нар дээрэмдэж, шатаахын хажуугаар бас байшин барьж байсан юм. Эндээс холгүй, Голын хөндийгаас нэг бээрийн зайтай байдаг юм. Боломж гарвал манайхаар ирдэг юм. Би хооллож ундлаад явуулдаг. Тэднийг хагас өлсгөлөн байлгадаг юм билээ. Зочин хүлээж авах, хооллохыг хатуу хориглосон л доо. Гэхдээ би тэдний тэр журмыг мөрдөнө гэж байхгүй! Уг нь би гэртээ байлгая гэж бодсон ч дарга нар мэдчихнэ, тэгвэл бид хоёулаа засангийн нүхэнд орно гэсэн үг.

- Танд их баярлалаа, ноён Кроттон, танд би насаараа өртэй боллоо. Тэр тусмаа аавтайгаа хурдан уулзах хэрэгтэй, тэр их удирдагч нь Шаркичтай нийлээд өглөө болохоос өмнө ямар нэг юм хийх байх.

- Өөрөө л мэд, залуусаас нэгийг нь дагуулаад яв, аавыгаа манайд аваад ир. Гэхдээ хуучин Нуурын Норгордыг тойрч яваарай. Миний хүү Жолл чамд газарчлаг.

Сэм Жоллийн хамт давхин одож, Мерри суурингийн эргэн тойронд болон зам дээр харуул гаргаад, Фродогийн хамт Кроттоныд очив. Дулаахан гал тогооны өрөөнд сууж, аялалынхаа тухай гэрийнхний асуултад хариулав. Гэвч голдуу өнөөгийн ажил хэргээ ярилцав.

- Хамаг хэргийг энэ Хатиг /Лоттог тэгж хочилдог болсон/ эхэлсэн юм. Ноён Фродо таныг алс газарт явсны дараахан л Хатиг ухаан нь самуурсан юм шиг болчихсон. Тэр ертөнцийн бүх юмыг хурааж аваад, хамгийн гол ганц эзэн болох гэсэн. Нэг харсан чинь л тэр бүх тээрэм, мухлаг, ферм, тамхины тариалан, пивоны үйлдвэрийг худалдаад авчихсан.

Тэр өөрөө хоосон байгаагүй л дээ. Эцэг нь өмнөд тойрогт байдаг газраа тэрэнд өгсөн. Тэр тамхи худалдаж эхэлсэн шиг байгаа юм. Хамгийн сайн тамхины өвсийг харь оронд жил гаруй нууцаар зараад байсан. Ноднингоос тамхины өвс байтугай юу ч байсан хамаагүй өмнө зүг рүү тэрэг тэргээр ил цагаан зөөгөөд эхэлсэн. Бид чих тавиад л хараад байсан, ардууд уурлаж эхэлсэн л дээ. Гэлээ ч гэсэн тэр юунаас айх билээ, тэрэг тэргээр ачаа авчраад байсан. Тэр дотор нь энэ үлэмж биет дээрэмчид сууж ирээд байсан юм билээ. Зогсоо зайгүй л ирээд байсан. Биднийг нүдээ ч цавчиж амжаагүй байхад тэд Хоббитани даяар мод цавчиж, газар ухаж, элдэв саравч дуртай газраа барьж эхэлсэн юм. Хатиг бүр цагаандаа гарч, шууд дээрэмддэг болсон.

Бага зэрэг шуугиан ч дэгдээсэн л дээ. Манай ахлагч хөгшин Вил эсэргүүцэл илэрхийлэхээр Уутан хясаа руу явсан боловч хүрч чадаагүй. Харуулууд нь түүнийг замд барьж аваад засангийн нүхэнд хийчихсэн, одоо ч тэндээ сууж байгаа биз. Тэгээд шинэ жилээс хойш бид ахлагчгүй болсон, Хатиг өөрийгөө ерөнхий ширриф гэж нэрлэх тушаал өгсөн, дараа нь Ерөнхий удирдагч гэж нэрлэхийг тушаасан.

Тэгээд л дарангуйлж гарсан даа. Тэдний хэлдгээр “эсэргүү зан гаргавал” засангийн нүхэнд хийнэ. Нэг үгээр хэлэхэд улам л гаараад байлаа. Татах тамхи ч байдаггүй, зөвхөн том дарга нарт л өгнө, пиво уухыг хориглосон, зөвхөн тэд л ууна, бүх мухлагийг хаасан, зооринууд хоосорсон, тэгсэн мөртөө дүрэм журам хэрээс хэтэрсэн. Жаахан хүнс нууж чадвал их аз, гэвч маргааш нь дээрэмчид ирээд хамаад авчихна. Тэгтэл Шаркич ирснээс хойш бүр ч амьдрах аргагүй болсон доо.

- Тэр Шаркич гэдэг нь хэн юм бэ? Биднийг нэг дээрэмчин тэр Шаркичийнхаа нэрийг барьж сүрдүүлсэн.

- Тэр хамгийн гол дээрэмчин нь юм шиг байна лээ. Есдүгээр сараас хойш л сураг нь гарсан юм. Хэн ч тэрнийг нүдээрээ хараагүй, Уутан хясаанд суудаг, тэр одоо Ерөнхий даргаас ч том дарга гэдгийг нь л мэднэ. Харуулууд тэрний хэлсэн бүгдийг хийдэг, тэр нь болохоор эвдэл, нураа, шатаа гэж л тушаадаг. Одоо бүр ал гэж тушаадаг болсон.

Хатиг Уутан хясаанд очингуутаа Пескунсын тээрмийг нураагаад, хэдэн хар царайтай үлэмж биетүүдийг авчирч оронд нь маш том тээрэм шинээр бариулсан. Хатиг аль болохоор их тариа тээрэмд гэж тушаасан. Дараа нь тэрэнтэй адил шинэ тээрэм олныг бариулсан. Гурил гаргах гэж тариа тээрэмддэг байтал тийм их тариа тээрэмдээд байгаа мөртөө гурил нь үзэгддэггүй. Пижигнэж нижигнээд л, бөөн хар утаа савсуулаад л, шөнө Норгордод унтах ч аргагүй болсон. Хажуугаар нь зориуд тэгж байгаа юм шиг газар ус хордуулаад л. Доод нуурыг хордуулчихсан. Тэндээс Брендидуим гол ойрхон шүү дээ. Хоббитанийг хоосон цөл болгох хэн нэгэнд хэрэгтэй юм шиг байна. Тэнэг Хатиг ийм юм хийхгүй, Шаркичийн заавар заавал байгаа.

- Тэр үнэн шүү! – гэж Том ярианд оролцож:

- Хатигийн эх, хүүгээсээ бусад хэн бүхний дургүйг хүргэсэн Любели эмгэнийг хүртэл хорьчихсон шүү дээ. Тэр эмгэн нэг өдөр шүхрээ барьчихаад гудамжаар явж байтал урдаас нь харуулууд асар их ачаатай том тэрэг чирж явжээ. Норгордынхон бараг бүгдээрээ харсан байна лээ.

- Энэ ачааг хааш нь авч яваа юм бэ? – гэж эмгэн асууж.

- Уутан хясаа руу.

- Яах гэж?

- Шаркичэд сарай барьж өгнө.

- Хэн зөвшөөрсөн юм бэ?

- Шаркич тушаасан юм, хөгшин хэрээ минь замаас зайл!

- Би та нарт тэр Шаркичийг чинь үзүүлээд өгье, өмхий хулгайч нар минь! – гээд эмгэн тэдний толгойлогчийн нүд рүү шүхрээрээ хатгах гэжээ. Даанч цаадах нь эмгэнээс хоёр дахин өндөр юм чинь яаж чадах вэ дээ. Эмгэнийг нас өндөр гэлгүй чирж аваачаад засангийн нүхэнд хийчихсэн гэсэн.

Тэднийг ийн ярьж байтал Сэм эцэг Жихараа дагуулан орж ирэв. Өвгөн Скромби бараг өтлөөгүй харагдавч чих нь нэлээд хатуурчээ.

- Сайн байна уу, ноён Торбинс! Таныг эрүүл энх, эсэн мэнд харахад өвгөн би их баяртай байна. Эргэж ирсэн чинь сайн. Тэхдээ намайг өршөөгөөрэй, та ажил хэргээр яваагүй шүү дээ. Уутан хясааг худалддаг чинь тоогүй, тэгэхдээ бүр хэнд худалдсан гээч? Тэгээд л энэ муухай үйл эхэлсэн юм шүү дээ. Сэмийн ярьсанд итгэх юм бол та нар харийн нутагт ямар нэг хар царайтай юмнуудыг уул руу хөөгөөд л явсан юм байх. Яах гэж тэгснийг чинь би Сэмээс асуугаагүй. Тэр хооронд энэ чөтгөрийн орхидосууд хүрч ирээд, цэцэрлэгийг минь ухаж, ногоог минь нохойд хаяад өгчихсэн! – гэж өвгөн Жихар үглэж гарав.

- Тийм юм болсонд намайг өршөөгөөрэй, ноён Скромби, гэвч би эргэж ирээд энэ балай байдлыг засах гэж хичээж байна шүү дээ – гэж Фродо хэлэв.

- Таны үг алт! Ноён Фродо удам сайтай нь харваас илт байна. Энэ овгийг зүүж гутаах хэрэггүй зарим нэг юмтай зүйрлэх юм алга, бүдүүлэг хэлсэнд уучлаарай. Миний Сэм ч гэсэн дээ, та энэнд сэтгэл хангалуун байгаа байх, дажгүй байсан биз?

- Дажгүйгээр барах уу, ноён Скромби, та итгэнэ үү, байна уу өөрөө мэд, одоо Сэм Дундад газар даяар алдартай, хүүгийн чинь тухай тэнгисээс энэ хүртэл, бас их мөрний цаана хүртэл дуу зохиож байгаа шүү.

Сэмийн царай улайж, Фродо руу талархалтайгаар харав. Учир нь, Розагийн хацар гэрэлтэн, царай нь энхрий инээмсэглэлээр гийж байлаа.

- Итгэхэд хэцүү л юм, гэхдээ энэ хүүхэд яваагүй газаргүй, үзээгүй юмгүй гэдэг нь харваас илт байна. Энэ нэг хантаазтай байсан юм, тэрнийгээ яачихсан юм бол доо. Хичнээн төмөр биендээ углаад толгойд юм нэмэгдэх биш, гэдэс нь л гялалзахаас өөр юмгүй – гэж Жихар хүүгээ өөлөв.

Үүр хаяархад Кроттоны гэрийнхэн болон зочид нь бүгд боссон байв. Шөнө тайван өнгөрсөн боловч энэ өдөр ихээхэн түгшүүртэй болох нь илэрхий байлаа.

- Уутан хясаанд харуулууд алга юм шиг байна, харин Уулзвараас нааш бөөн бөөнөөрөө ирцгээж байгаа бололтой - гэж Кроттон хэлэв.

Өглөөний цайгаа ууж байтал Молтогчний хөндийгөөс нэг элч баяр хөөртэй давхиж ирэв:

- Хоббитани даяараа босоод байна. Түймэр л гэсэн үг. Амьд үлдсэн хамгаалагчид өмнө зүг рүү сүүлээ хавчаад зугтсан. Бусад эрчүүд бүгдээрээ ноён Перегриний хороонд нийлсэн – гэж тэр мэдээллээ.

Бас нэг мэдээ ирсэн нь муу мэдээ байв. Цурам ч хийлгүй шөнийг өнгөрүүлсэн Мерри арван цагийн үед ирэв:

- Ойролцоогоор дөрвөн бээрийн цаана дайсны том отряд ирээд байна. Уулзвараас болон замаасаа цуглуулжээ. Зуу гаруй хүн замдаа тааралдсан бүхнийг галдаад л наашилж байна. Ийм л хорон шулмасууд байгаа юм!

- Тэд ч хэлэлцээ хийх гэж яваа биш, манийгаа төхөөрөх гэж яваа нь лавтай. Молтогчингийнхон амжиж ирэхгүй бол бид сайн нуугдаж аваад харваад байхаас өөр замгүй. За ноён Фродо, хүссэн ч хүсээгүй ч алалдах л болж дээ – гэж Кроттон хэлэв.

Молтогчингуудын хороо амжиж ирлээ. Пин Молтогчингийн хөндий болон Ногоон толгодоос зуу гаруй зэвсэгт эрчүүдийг удирдан сууринд орж ирлээ. Одоо Мерри дайсантай тулалдах хангалттай хүчтэй боллоо. Дайснууд бослого гарсныг мэдсэн, түүнийг Голын хөндийгөөс гаргалгүй дарахаар яаран ирж явна гэж тагнуулчид мэдээлэв. Дайснууд хар хор, уур хилэн нь буцалж байгаа боловч цэрэг дайны ямар ч мэдлэггүй нь илт байв. Тэд төв командын байр ч байхгүй, толгойн сэргийлэх анги ч байхгүй, ядаж тагнуул ч илгээгээгүй ажээ. Мерри байлдааны төлөвлөгөөг тэр даруй зохиов. Дайснууд зүүн замаар орж ирээд, Голын хөндий рүү эргэлээ. Тэнд замын хоёр талын эгц хажуу дээр, зайгүй эгнүүлэн тарьсан өндөр саглагар бутнуудын ард хоббитуудын отоо байрласан байв. Гол замаас зургаан зуун алхам зайд тэрэгнүүдийг гурав давхарлан хажуулдуулж, хоббитууд хориглосон байв. Дайснууд бөөнөөрөө тэнд хүрч ирэхэд замын хоёр талд нуугдаж байсан хоббитууд ард нь үлдээд, тариан талбайд нуусан тэрэгнүүдээр хоромхон зуурт бэхлэлт босгон хориглож ухрах замыг нь хаалаа. Дайсан отолтод орж ирэхэд Мерри:

- Та нар уучлаарай, отоонд орчихлоо. Норгордод байсан нөхдөөс чинь нэг нь алагдсан, бусад нь хоригдож байгаа. Зэвсгээ хаяад! Хорин алхам ухраад, хөдөлгөөнгүй сууцгаа! Хөдөлсөн бүхэн үхнэ! – гэж мэдэгдэв.

Энэ удаа тэднийг айлгах тийм ч амархан биш байлаа. Зарим нь Меррийн үгэнд орсон боловч толгойлогч нь тэр дор нь журамд оруулав. Хориод нь эргэж зугтаасан ба зургаа нь хоббитуудын суманд сүлбүүлэн унаж, бусад нь бүслэлтээс гарч амжлаа.

- Хол гүйхгүй, цаана нь манай харваачид байраа эзэлсэн, үхэл рүүгээ гүйцгээж байна – гэж Пин хэлэв.

Хоёр нь уналаа. Мерри бүрээгээ үлээхэд тал бүрээс хариу бүрээдэв.

Зам дээр дөрвөн талаасаа бүслэгдсэн наяд харуул шууд урагшаа дайран хориглолтыг дайран гарахыг оролдлоо. Хоббитууд олныг харваж, олныг цавчиж унагаалаа. Хамгийн хүчтэй, хамгийн шийдсэн дайснууд баруун тийш тэмүүлж, амь хайргүй тулалдаан нэлээд хэдэн хоббитийн аминд хүрсэн боловч хариугүй сэтлэн гардгийн даваан дээр зүүн талаас Мерри,

Пин хоёр амжин ирж, Мерри дайсны толгойлогч, орх үүлдрийн нүсэр том хялар нүдэт этгээдийг цавчин унагав. Дараа нь Мерри бүслэлтээ задлахад үлдсэн дайснууд алсуур хүрээлсэн харваачдын сумны бай болов.

Ингээд байлдаан дууслаа. Дал орчим дайсны хүүр гулдайж, дөчөөд нь олзлогдов. Арван есөн хоббит алагдаж, гучаад нь шархаджээ. Дайсны хүүрүүдийг тэдний ухсан элсний уурхайд булаав. Алагдсан хоббитуудыг уулын энгэрт нийтээр нь оршуулан хөшөө болгож, төгөл суулгав. Ийнхүү Хоббитани оронд хамгийн сүүлчийн дайн 1419 онд болж өнгөрчээ. Дайнд оролцогчдын нэрсийг их жагсаалтад оруулж, Улаан номонд байлдааны тухай бүлэг оруулжээ. Жагсаалтын эхэнд Мериадок, Перегрин хоёрын нэр дурайж байлаа.

Тулалдааны дараа цаашид юу хийхээ ярилцахаар Фродо, Мерри, Пин, Сэм нар Кроттоныд цугларав. Үдийн хоол идсэний дараа Фродо:

- За одоо явж Ерөнхий удирдагчтай тооцоо бодох уу даа.

- Зүйтэй, хичнээн түргэн бол төчнөөн сайн. Гэхдээ тэнд очоод чи битгий нялцганаад байгаарай. Харуулууд бол тэрний гар хөл байсан, хариуцлагыг нь тэр л хүлээх ёстой – гэж Мерри хэлэв.

Кроттон тэдэнтэй хориод чийрэг залуусыг хамт явууллаа.

- Ууган хясаанд харуулууд үлдээгүй нь лавгай, гэвч юмыг яаж мэдэхэв – гэж тэр хэлэв.

Фродо, Сэм, Мерри, Пин гурав цэргүүдээ дагуулан хөдлөв. Тэр дөрөвт урьд өмнө хэзээ ч байгаагүй уйтгартай байлаа. Учир нь урд талд нь нүсэр том хар яндан хаа холоос хар утаа суунаглуулан харагдсаар, хуучин нуурын тосгонд дөхөж иртэл замын хоёр талаар эгнүүлэн барьсан яйжгар саравчнууд, нүдэнд хүйтэн, уруу царайтай шинэ тээрэм, гол дээгүүр тэгнүүлэн барьсан тоосгон байгууламж гол руу утаа савссан хаягдлаа хийж байгаа үзэгдэв. Голын хөндийн замын хоёр талын бүх модыг нэгд нэггүй хяргажээ.

Тэд гүүрээр гарч, Ууган хясаа руу хараад дуу алдан халаглав. Сэмийн шидэт толинд харсан юмнаас ч долоон дор үзэгдэл тосов. Гол замын баруун талд байсан эртний байшинг нурааж, буурин дээр нь давирхай түрхсэн муруй сарий саравчнууд барьжээ. Голт борын бутан төглийг оргүй болтол харгасан байв. Энд тэндгүй газар ухаж, эгнүүлэн тарьсан бутнуудыг хожуул болгожээ. Нүцгэн болсон тариан талбайд тэрэгнүүд овоорчээ. Скрэмбийн эдлэн газарт элс, хайрганы уурхай онгойн харлаж, энд тэндгүй элс хайрга овоолсон байна. Хоёр давхар амбааруудын цаанаас Ууган хясаа ч үл үзэгдэнэ.

- Цавчаад хаячихаж, үхээрүүд чинь! Баярын модыг минь унагачихжээ! – хэмээн Сэм арван найман жилийн өмнө Бильбо салах үгээ хэлж байсан газар руу заав. Тэнд баярын модны өмхөрсөн гол сэрийн хэвтэж байв. Энэ арай дэндсэн хэрэг байсан тул Сэм енгэнэтэл уйлав.

Гэвч түүний дууг чанга инээх дуу тасаллаа. Тээрмийн намхан хашааг тохойлдон зогссон хамаг хувцас нь тос болсон, халтар царайтай бүдүүн хоббит:

- За яав, Сэмхэн минь, таалагдахгүй байна уу? хэмээн тэр хо хо хо хөхөрч:

- Чи ер нь дандаа л нус нулимс болж байдаг даа. Чамайг би хаа нэгтгээ харь газарт онгоцоор хөвж яваа гэж бодсон юмсан. Чи дандаа л тэгж донгосдог байсан шүү дээ. Яагаад эргээд ирээв? Бид Хоббитанид ажил хийж байна, чухал юм хийж байна, ойлгов уу чи.

- Харваас тийм байна. Нүүрээ ч угаах завгүй, гэдсээрээ хашаа будах л үлдэж дээ. Харин чи сонс, ноён Пескунс гуай, би тооцоо бодохоор эргэж ирсэн юм. Хэн шүдээ ярзайлгана, тэр болгонтой тооцоо хийнэ, их үнэ төлөх болно шүү!

- Чөтгөр рүүгээ тонил! - гэж Тод Пескунс хашаан дээгүүр нулимаад:

- Намайг оролдоод үзээрэй. Би их удирдагчтай найз. Тэр чамайг нэг болгоод өгнө вий.

- Энэ тэнэгийг зөнд нь орхи, Сэм! Ингэж эвдэрсэн амьтан хоёр гуравхан л байгаа, тийм биш байсан бол бидний ажил балрах байсан. Энэ л хамгийн том аюул, бусад хоосролоос илүү аюул – гэж Фродо хэлэв.

- Хөөе Пескунс, Пескунс, халтар хоншоор оо, дээр нь бас балай тэнэг ээ, нүдээ арч! Бид яг одоо чиний найз их удирдагч руу чинь явж байна, чихдэж гаргаж ирээд нар харуулна. Харин чи том дарга нартайгаа салах ёс гүйцэтгэхээ мартсан юм биш үү - гэж Мерри хэлэв.

Меррийн дохиогоор гүүрний цаанаас зэвсэгт отряд гарч ирэхийг хараад Тод амаа ангайсан чигтээ хөшиж орхив. Тэр тээрэм рүү гүйж ороод том бүрээ гаргаж ирэн бүрээдэв.

- Битгий бархираад бай! Чамгүйгээр болно! – гэж Мерри хэлээд мөнгөн бүрээгээ өргөж, цангинасан чанга уриа цууриатуулахад тал талаас хоббитууд хариу хашгиралдан нүхэн байр, саравчнуудаас хоббитууд гүйлдэж ирээд отрядын араас бөөнөөрөө Уутан хясааг зүглэв. Дээр гараад бүгдээрээ зогсч, Фродо найзуудтайгаа түрүүлэн явлаа. Тэр танил, дотно байшиндаа эргэн ирлээ.

Цэцэрлэг нь оргүй алга болж, буурин дээр нь баруун тийшээ харсан цонхтой саравч, амбаарууд нарны гэрэл хаан шавааралджээ. Хаалга нь нэлдээ зурагдаж халтартсан, гинжин хонх нь тасарч унжжээ. Хичнээн ч хонхдож, тогшоод хариу өгсөнгүй. Эцэст нь мөрлөн түлхэхэд хаалга онгойв. Урдаас нь хүйтэн, илжирмэл, үхэнгэ үнэр гарахыг бодвол байшин хоосон бололтой.

- Тэр нохой Лотто хаашаа алга болчихдог байна аа? Бүх саравч, нүхнүүдийг нь нэгжүүлдэг юм бил үү – гэж Мерри гайхав.

Тэд бүх тасалгаагаар ороход харх хулгануудаас өөр нэг ч амьд амьтан алга.

- Мордороос ч дор юм байна, бүр долоон дор гээч! Байшин нь ямар байна, эзэн нь тийм гэж ярьдаг даа. Манай байшинг танигдах аргагүй болтол сүйтгэж, бузарлаж орхижээ! – гэж Сэм дуу алдав.

- Тийм ээ, энэ бол Мордорын үхдэл. Саруман үхдлүүдийг үржүүлсэн байна. Мордорын эзний

гол зорилго энэ л байсан юм. Саруман өөрөө бүгдийг мэхэлсэн гэж бодож байсан. Тэнэг Лотто тэр зорилгыг нь биелүүлсэн байна.

Мерри эргэн тойрноо ууртай, ой гутсан шинжтэй харж зогсов:

- Эндээс явцгаая! Тэр ийм юм хийхийг нь мэдсэн бол би тэрний хоолой руу тамхины хүүдийгээ чихэх байсан юм!

- Тэгэх байтугай л юм болох байсан! Даанч мэдээ ч үгүй, чихээ ч үгүй л байна. Тиймээс та бүхэнтэй мэндчилж, байшиндаа урихыг зөвшөөрнө үү!

Хаалганы дэргэд Саруман өөрийн биеэр, цатгалан, сэтгэл хангалуун, хөгжилтэй бөгөөд хорсолтой инээмсэглэн зогсч байв.

Тэгмэгц Фродогийн толгойд нэг бодол гялсхийж:

- Шаркич! – хэмээн дуу алдав.

Саруман тачигнатал инээлээ.

- Чи бас миний нэрийг сонсчихоо юу? Миний боолууд Изенгардад намайг тэгж нэрлэдэг байсан юм. Надад сайн байсан юм байлгүй дээ. (Орхийн хэлээр “шарку” гэдэг нь “өвгөн” гэсэн утгатай ажээ.) Гэвч ямар сонин уулзалт вэ, та нар намайг энд харна гэж зүүдлээ ч үгүй биз дээ?

- Үгүй ээ, гэхдээ таамаглаж болох байсан. Гэндальф чамайг жижиг сажиг хорон муу үйл хийх чадалтай хэвээрээ байгаа гэж бидэнд анхааруулсан юм.

- Байлгүй яахав, байлгүй яахав, гэхдээ тийм ч жижиг сажиг биш шүү. Ертөнцийн шинэ эздийн дагуулуудын дунд орчихсон их зантай одойнуудыг харахад их инээдтэй байсан шүү. Та нар мөн ч их сэхүүн байсан даа! Уснаас хуурай гарсан, үүрэндээ буцаж очоод юу ч болоогүй юм шиг амьдарна гэж бодсон биз. Саруманы цамхаг яахав дээ! Түүнийг нурааж болно, эзнийг нь хөөж болно, харин манай байшин, манай цайз. Иймээ тиймээ юм болвол Гэндальф биднийг хамгаална гэж бодсон уу?

Саруман дахиад тачигнатал хөхрөв:

- Гэндальф уу даа! Та нар түүнд үйлчлээд дууссан, одоо тэр та нараар юугаа хийх юм бэ? Та нар ам хуурайгүй шулганалдаад л тэрнийг дагаж тойруу замаар явсан. Тэгэхээр чинь би та нар ийм тэнэг юм бол жаахан түрүүлж очоод зохих сургамжийг нь өгье байз гэж бодсон юм. Даанч цаг, бага, хүн хүч ч бага байлаа. Тиймгүйсэн бол миний сургамжийг та нар насандаа мартажгүй байсан юм. Гэхдээ яах вэ, хангалттай, би танай энд сайхан эзэгнэсэн. Ядаж та нарт ч гэсэн гомдлоо тайлж чадсандаа би эргэн дурсахад санаа амар байх болно!

- Хэрэв чи зөвхөн энүүхнээр санаагаа амраах гэж байгаа бол би чамайг өрөвдөж байна. Хоосон санаа гэж айж байна. Одоохон яв, үүрд үзэгдэхээ боль! – гэж Фродо хэлэв.

Саруман оромжоосоо гарч явахыг хоббитууд харлаа. Тэд Уутан хясааны хаалган дээр баргар царайлан ирээд Фродогийн саяны үгийг сонсмогц хилэнтэйгээ хашгиралдав:

- Тэрнийг битгий явуул! Тэрнийг алах хэрэгтэй. Тэр бол хар үйлт, цус сорогч. Тэрнийг алья!

Саруман хоббитуудын дайсагнасан царайг доогтой инээвхийлэн харж байв.

- Алцгаа алцгаа, оролдоод үз, зоригтой хоббитхонууд минь. Энд алуурчид та нар зөндөө олуул ирснийг би харж байна – гээд тэр нуруугаа эгцлэн сүрлэгээр зогсоход хар нүд нь сүртэй гялалзав:

- Харин хамаг байдгаа цөлмүүлсэн намайг ид шидээ алдчихсан гэж битгий л бодоорой доо. Хэн надад гар хүрнэ, тэр аймшигтай үхлээр үхнэ шүү. Миний цус Хоббитанийн шороон дээр урсвал танай газар нутаг үүрд үржил шимгүй болно шүү.

Хоббитууд ухрав. Тэгэхэд нь Фродо:

- Түүний үгэнд бүү итгэ! Тэрэнд ямар ч ид шид байхгүй, зөвхөн дуу хоолой нь эрхэндээ оруулан мэхэлж байгаа юм. Гэхдээ түүнийг алахыг би зөвшөөрөхгүй. Өсийг өсөөр хариулж болохгүй. Тэгвэл ертөнцөд зөвхөн хар муу үйл л үлдэнэ. Саруман, нэн даруй яв!

- Өмхий! Хөөе Өмхий! - хэмээн Саруман хашгирахад хамгийн наад захын саравчнаас Өмхий Амт яг л зодуулсан нохой шиг дөрвөн хөллөн гарч ирэв.

- Замдаа гаръя, Өмхий! - хэмээн Саруман тушааж: - Нөгөө хөөрхөн ноёд чинь энд бас хүрээд ирлээ, биднийг хөөж байна. Алив явъя!

Өмхий Амт Саруманы араас салгалав. Саруман Фродогийн хажуугаар өнгөрөхөд түүний гарт кинжаал гялсхийн, тэр нүд ирмэх зуурт асар хүчтэй шаав. Гэвч кинжаал нь хувцсан дотуур өмссөн мифрил хуягнаас ойж, хуга үсэрлээ. Сэм тэргүүтэй арваад хоббит ухасхийн бүтэлгүй алуурчийг газарт хөсөр унаган дарж авлаа. Сэм илдээ сугалав.

- Хэрэггүй ээ, Сэм! Ямар ч гэсэн наадахаа алж хэрэггүй. Хар хорондоо шатаж байгаа үед нь бүр ч болохгүй. Нэгэн цагт наадах чинь бид өөдөөс нь гар өргөх эрхгүй агуу шидтэн байсан юм. Энэ одоо сөнөсөн, үүнийг бид шийтгэх хэрэггүй. Хар санаанаасаа салах ч юм бил үү, хэн мэдлээ – гэж Фродо өгүүлэв.

Саруман босч, хүндэтгэн гайхсан, гүнээ үзэн ядсан харцаар ширтэж байв

- Тийм ээ, чи үнэхээр их өссөн байна, жижиг биет минь, маш их өссөн байна. Чи бүр мэргэн бөгөөд харгис хатуу болсон байна. Одоо чамаас болоод миний өс санасан сэтгэл хэзээ ч тайтгарахгүй. Чиний өршөөл надад ертөнцийн хамгийн гашуун зовлон болно. Чамайг болоод нинжин сэтгэлийг чинь үзэн ядаж байна би! За за, явлаа, дахиад сэтгэлийг чинь түгшүүлэхгүй. Гэвч найдах хэрэггүй, би салахдаа чамд эрүүл энх, урт нас ерөөхгүй. Яагаад гэвэл аль нь ч байхгүй болно. Харин үүнд би буруугүй шүү. Би зүгээр л чамд урьдчилан хэлж байна.

Тэр явж өнгөрөхөд хоббитууд зэвсгээ чанга атган, зам тавьж өгөв. Өмхий Амт араас нь сажиллаа.

- Өмхий Амт! Чамд өөр зам байж болно шүү дээ. Чи надад ямар ч хор хүргээгүй. Амарч, биеэ тэнхрүүлж аваад өөрийнхөө замыг хөөж болно – гэж Фродо хэлэв. Өмхий Амт зогсч, бараг л үлдэх маягтай өрөвдөлтэйгээ эргэж харав. Саруман ч эргэж харлаа:

- Хор хүргээгүй гэнэ ээ? – гээд тэр хи хи инээж:

- Юун хор мор! Шөнө ч гэсэн наадах чинь зөвхөн од харах гэж л гадагш мөлхөж гардаг юм. Ингэхэд хэн нэг нь Лотто хаашаа алга болчихов гэж асууж байсан байх аа? Өмхий чи тэрнийг хаашаа алга болсныг мэдэж байгаа шүү дээ. Хэлээд өгчихөөч!

- Үгүй үгүй! – гэж Өмхий уйлагнав.

- За за, тэр ч яахав, наадах чинь танай хайрт удирдагчийг алсан юм. Яасан бэ, Өмхий, худлаа юм уу? Үнэн шүү дээ! Нойрон дунд нь алсан гэж би бодож байна. Тэгээд булчихсан, гэхдээ юу л бол. Өмхий дандаа ийм өлсгөлөн байдаг юм. Та нар энүүгээр юугаа хийхэв дээ. Энэ бузрыг надтай явуулчих.

Өмхий Амтын улаан нүд галзуу мэт гялалзав:

- Чи надад тэрнийг ал гэж тушаасан, чи надаар алуулсан.

- Өө, Өмхий чи дандаа Шаркич миний хэлснийг хийдэг юм уу? – гээд Саруман учиргүй чанга инээснээ:

- Тэгвэл Шаркич чамд тушааж байна. Миний хойноос!

Тэр дөрвөн хөллөсөн хэвээр байгаа Өмхийг хүчтэй өшиглөхөд цаадах нь үг дуугүй дагав. Гэтэл огт санаанд оромгүй юм болж. Өмхий Амт гэнэт босон харайж, хувцсандаа нуусан хутгаа гаргаж ирээд нохой мэт архиран ухасхийж, Саруманы нуруун дээр үсрэн гараад хоолойг нь хэрччихээд орь дуу тавин зугтаав. Фродо амаа ч ангайж амжаагүй байтал гурван сум Өмхий Амтыг газарт хадав.

Саруманы дээгүүр саарал манан бөөгнөрснөө том түүдэг галын утаа шиг удаанаар хөөрөн Уутан хясаан дээгүүр асар том манант үүл болж хувирахад бүгд айлаа. Үүл баруун тийш хурдлан нүүтэл тэр зүгээс хүйтэн салхи үлээж, үүл замхрав. Фродо түүний хүүр рүү өрөвдсөн, айсан нүдээр хартал хүүр гэнэт татгасхийж, мянган жилийн үхлийг ил гаргав. Ярзайсан хохимойд наалдаж хатсан арьс л үлдэв. Фродо уранхай цуваар нь бүтээгээд нүүр бурууллаа.

- Аятайхан төгсгөл байна, үгүй ээ, муухай төгсгөл байна. Би үзэх хэрэггүй л байсан юм, гэвч арай гэж нэг юм саллаа гэдэг биз дээ – гэж Сэм хэлэв.

- Миний бодлоор бол дайн дууслаа – гэж Мерри хэлэв.

- Тэгэж найдья, тэгэхдээ бүр Уутан хясаан дээр дуусдаг байна шүү! Энийг ч ёстой зүүдлээ ч үгүй дээ – гэж Фродо хэлэв.

- Дууслаа гэнэ шүү, зуун жил малтаж барахааргүй хог тарьсан шүү дээ - гэж Сэм бувтналаа.

Бүлэг 19

Мөнгөлөг боомт

Ажил үнэхээр их байсан нь мэдээж боловч Сэмийн хэлсэнчлэн зуун жил үргэлжилсэнгүй. Тулалдааны маргааш өглөө нь Фродо нар засангийн нүхний хоригдлуудыг суллахаар Газарухуур руу явав. Хамгийн түрүүнд одоо нэгэнт Бүдүүн хоч нь тохирохоо больсон хөөрхий Фредегар Минжийг сулав. Тэр Доргын хөндийгөөс босогчдын отрядыг нууцаар шилжүүлэн байрлуулж байхдаа баригдсан ажээ.

- Чи бидэнтэй хамт явсан бол ингэж яс ярьс болохгүй байсан даа, Фредик гэж Пин түүнийг нүхнээс тэврэн гаргаж байхдаа хэлэв. Фредегар хөл дээрээ тогтож чадахгүй байлаа.

Цаадах нь нэг нүдээ нээж, баатарлагаар инээмсэглэсэнээ:

- Энэ аянга шиг чанга дуутай залуу баатар чинь хэн бэ? Нөгөө жижиг Пин арай биш биз дээ? Одоо чи тоглойдoo багтах малгай хаанаас олж авна даа – гэж шивнэв. Дараа нь шулам Любелийг гаргалаа. Хөөрхий тэр амьтан бүр тартагтаа тултал хөгширч, яс арьс болтлоо турсан боловч харнхуй, давчуу нүхнээс гаргахад “Би өөрөө явна” гэж хэлээд шүхрээ тулж, Фродог түшин гарав. Түүнийг баяр хүргэн хашгиралдаж угтахад хөөрхий амьтан уйлж, нулимсандаа хахаж цацсаар явав. Тэр хэзээ ч, хэнд ч муугаа үзүүлэхгүй гээд их л хатуу ширүүн байдаг байсан учир уйлж байгааг нь харахад сонин байв. Лотто алагдсан тухай мэдээ түүнийг бүр ч доройтуулж, тэр Ууган хясаа руу явсангүй. Фродод буцааж өгөөд, садан төрлийн Цүндгэрийнхэн рүүгээ явав.

Хөөрхий эмгэн хавар нь зуу гаруй наслаад өөд болж, өөрийнхөө бүх хадгаламж болон Лоттогийн бүх хөрөнгийг орон гэргүй хоббитуудад байшин бариулахаар Фродод гэрээсэлснийг мэдээд Фродо ихэд гайхахын зэрэгцээ талийгаач эмгэнийг их өрөвджээ. Ингээд нэгэн үеийг элээсэн хэрүүл тэмцэл эцэс болов.

Хөгшин Вил Дэвсүүртавхай засангийн нүхэнд бүгдээс удаан суусан бөгөөд бусдыгаа бодвол муугүй хооллож байсан боловч их дор орсон тул Хоббитанийн ахлагч болгоход дахиад нэлээд идүүлэх шаардлагатай байв. Түүнийг тэнхэртэл ахлагчийн үүрэг гүйцэтгэхийг Фродо зөвшөөрөв. Ахлагч болоод тэр ширрифүүдийг тарааж, шаардлагатай цөөхнийг нь албанд үлдээгээд, бусдыг нь бусдын хэрэгт хушуу дүрэлгүй өөрсдийнхөө ажлыг хий гэж тушаав.

Пин, Мерри хоёр дайсны үлдэгдлүүдээс Хоббитанийг цэвэрлэх үүрэг хүлээж, богинохон хугацаанд амжилттай биелүүлжээ. Голын хөндийд болсон байлдааны тухай сонссон дээрэмчид өмнө зүг рүү зугтаасан бөгөөд Хоббитанийн шуурхай отряд тэднийг хаана л бол хаана гүйцэж байлаа. Сүүлчийн дээрэмчдийг хязгаарын ойд бүслэн авч, зүйл дуусгаад амьд үлдсэнийг нь хилээр гаргав.

Энэ хугацаанд Хоббитани орон хуучин хэвдээ орж, Сэм толгой өндийх завгүй байлаа. Яг цагаа болохоор хоббитууд зөгийнөөс ч ажилсаг ажээ. Хүүхэд хөгшид, эр эмгүй хөдөлмөрлөв. Хүүхдийн хурдан, уян гар, хөгшдийн эвэр ургасан шөрмөслөг гар адилхан хэрэгтэй байв.

Шаркичийн бариулсан саравч, амбааруудаас ширхэг тоосго, ширхэг банз ч үлдээсэнгүй, бүгдийг нь ашигтай зарцуулжээ. Хуучин нүхэн байруудыг засч, дулаалав. Олон газар нуусан хоол хүнс, пивоны агуулахуудыг олж, зуны дунд сарын баяр, өвлийн дунд сарын баярыг элбэг дэлбэг тэмдэглэлээ. Энэ бол ёстой санаанд ороогүй их олз байлаа.

Норгордод шинэ тээрмийг буулгаж дуусаагүй байхад Уутан хясааг хог новшноос цэвэрлэж, Исторбинкийн цэцэрлэгийг шинээр байгуулав. Хясааны өмнө талд шинэ нүхэн байрууд барьж, тоосгоор доторлолоо. Жихарь дахиад л № 3 байранд оржээ.

Ой модонд хамгийн их хохирол учирсан байсан бөгөөд Шаркичийн тушаалаар тааралдсан мод болгоныг унагаж байсан учир Сэм яахаа ч мэдэхгүй сэтгэл түгшин бодлогоширч явдаг болов. Хоббитани орон ямар ойтой байсныг хэдэн үеийн дараа л үзэх байх гэж тэр санааширч байлаа. Гэтэл нэг удаа элдэв ажилтайгаа ноцолдож байхдаа тэр гэнэт Галадриэлийн бэлэглэсэн хайрцгийг санав. Тэгээд хайрцгаа авч найзууд /тэднийг одоо аялагчид гэхээс өөрөөр нэрлэхээ больжээ/ дээрээ очоод юу гэж хэлэхийг нь сонсов.

- Би чамайг хэзээ үүнийг санах юм бол доо гэж бодоод байсан юм, нээгээтэх! – гэж Фродо хэлэв.

Дотор нь саарал тоос, мөнгөн хальстай самар шиг жижигхэн үр байв.

- Одоо тэгээд яах вэ? - гэж Сэм асуулаа.

- Чи бүгдийг нь нэг салхитай өдөр салхинд хийсгэчих, тэгээд юу болохыг нь харъя – гэж Пин зөвлөв.

- Юу харах юм бэ?

- Эсвэл талбай сонгож аваад тэндээ суулгачих, тэгээд юу гарахыг нь харахгүй юу – гэж Мерри хэлэв.

- Хатан хаан зөвхөн ганц надад энийг өгөөгүй байх, бүгдээрээ л адилхан зовж зүдэрч байна – гэж Сэм зөрлөө

- Чи бол манай цэцэрлэгч, тиймээс бэлгээ өөрөө мэдэж хэрэглэ, харин аль болохоор ашигтай, гамтай хэрэглээрэй. Энэ тоосны ширхэг бүр нь жин алтны үнэтэй байх – гэж Фродо хэллээ.

Тэгээд Сэм хамгийн гое, хайртай моднууд нь байсан газартаа тооснуудыг ширхэг ширхэгээр нь суулгав. Тэрбээр Хоббитанийн нутгаар хөндлөн гулдгүй явж, хамгийн түрүүнд Голын хөндий, Норгордод үрээ суулгав. Зөөлөн саарал тоос тун цөөхөн ширхэг үлдэхэд тэр Хоббитанийн нутгийн төвд байдаг Гурван тойргийн чулуунд очоод үлдсэн үрнүүдээ дөрвөн зүгт хийсгэж, тарни уншив. Мөнгөлөг үрээ баярын мод байсан газарт суулгалаа. Юу л ургана, тэр нь ургаг гэж тэр дотроо бодов. Тэр өвөлжингөө байн байн суулгасан үрнүүдээ эргэж байлаа.

Гэтэл хавар нь ёстой гайхамшиг гэгчийг үзэв.... Суулгацууд нь нэг жилд хорин жилийг

багтааж байгаа юм шиг хурдан бөгөөд өндөр ургах нь тэр. Баярын модны буурин дээр мод ургасангүй, зүгээр л суга үсрээд гараад иржээ. Мөнгөлөг хальстай, уртавтар навчтай ер бусын гоёмсог цэл залуу мод дөрөвдүгээр сар гэхэд л алтлаг өнгийн цэцэгсээр хучигдав. Тэр мод яах аргагүй мэллорн байсан бөгөөд тойргийнхон бүгдээрээ ирж сонирхжээ. Дараа нь тэр мод үгээр илэрхийлэхийн аргагүй үзэмж төгс болоход алс хязгаараас ирж харцгаадаг болов. Манант уулсаас баруун тийш, Тэнгисээс зүүн зүгт байх ертөнцийн хамгийн гоо сайхан цор ганцхан мэллорн гээд бодохоор үнэхээр тэгэх ёстой байлаа.

1420 он үлгэрийн юм шиг сайхан жил гарав. Наран эелдгээр ээж, бороо яг цагаа олж, зөөлөн, өгөөмөр шивэрч, агаар балын амтаар сэнгэнэн, угаасаа богинохон зунтай дундад газарт хэзээ ч байгаагүй намуухан сайхан, бүх юм гэрэл гэгээтэй байлаа. Тэр жилийн хүүхдүүд эрүүл чийрэг, гоо сайхан, ихэнх нь хоббитуудын дунд нэн ховор намирсан алтлаг шаргал үстэй төрж байв. Үндэстэй бүхэн үлэмж ихээр урган цэцэглэсэн тул хоббит хүүхдүүд жимсэнд умбаж, амаараа гартал идэж, чавганы ясыг овоо болтол овоолжжээ. Нэг ч хоббит өвчин эмгэгт нэрвэгдсэнгүй, бүгдээрээ хөгжил баясгалантай, санаа амар жаргаж байлаа. Харин өвс ногоо дэндүү өтгөн ургасан тул хадланчид л ажил ихтэй.

Өмнөд тойрогт “гаансны өвс” хэтэрхий баян ургасан тул ургацаа арай ядан хурааж, амбаарууд задартлаа дүүрэв. Умард тойрогт арвай хачин сайхан ургасан учир тэр жилийн пивийг дахиад хорин жил дурсан ярьсан билээ. Ядартлаа ажилласан өвгөн орой нь нэг хоёр гүрүүшиг пиво уучихаад:

- Ёстой сайхан пиво байна, яг л хорин оных шиг! – гэдэг болсон билээ.

* * *

Сэм эхлээд Фродогийн хамт Кроттоны байшинд суудаг байснаа шинэ хороолол баригдсаны дараа Жихарийнд суудаг болов. Ургац хураалт болоод Уутан хясааны барилгын ажлыг ойрхноос удирдах хэрэгтэй байлаа. Энэ ч яахав мэдээж хэрэг, хажуугаар нь тэр ерөнхий ойчийн хувьд Хоббитани даяар аялдаг байв. Гуравдугаар сарын эхээр тэр гэртээ байгаагүй учир Фродогийн бие алжаасныг мэдсэнгүй. Фермер Кроттон арван гуравны өдөр ажил төрөл ярилцахаар Фродогийн өрөөнд ортол тэр мөнгөн оосртой сувдан зүүлтээ тас атгаад, халуундаа дэмийрэн хэвтэж байв.

- Тэр үүрд алга болсон, одоо газар сайгүй харанхуй, хоосон болсон – гэж дахин давтан хэлж байв.

Гэвч удалгүй илаарь болж, хорин таванд Сэмийг ирэхэд тэр зүв зүгээр болсон байсан бөгөөд тэр талаар юу ч ярьсангүй. Тэр хооронд Уутан хясааг хэвийн байдалд нь оруулж, Мерри, Пин хоёр Молтогчингийн жалганаас нүүж ирэхдээ бүх тавилга, ахуйн хэрэгслүүдээ авчирсан учир тохилог том байшин нь хуучин хэвдээ оржээ.

Бүх юм бэлэн болсон хойно Фродо хэлэв:

- Сэм, чи хэзээ манайд нүүж ирэх гэж байна?

Сэм түгдрэв.

- За яараад яахав дээ. Жихарь хажууханд байна. Бэлэвсэн авгай Хүрэнмуужиг өвгөнийг бараг гар дээрээ өргөх шахам байгаа шүү дээ – гэж Фродо хэлэв.

- Юу л даа, ноён Фродо... – гэж Сэм хэлээд царай нь намуу цэцэг шиг улаан болов.

- Би нэг л ойлгосонгүй.

- Сарнайхан, яагаав дээ Роза Кроттон, тэр намайг тантай хамт явахад их дургүй байсан юм байх аа. Тэгэхэд би түүнд шууд хэлээгүй болохоор тэр дуугүй байж л дээ. Одоо би түүнд энээ тэрээ юм ярихаар “Чи жил гаруй дэмий тэнэлээ, одоо ухаан орох цаг болсон” гэлээ. Шулуухан хэлэхэд би одоо хоёр хэсэг болчихоод байна.

- Одоо л ойлголоо. Чи гэрлэхийг хүсч байна. Тэгсэн мөртөө намайг орхихыг хүсэхгүй байна, тийм үү? Сэм минь, энэн шиг амархан юм байхгүй. Розатайгаа энд хүрээд ирээч! Маргааш ч гэсэн болно, гэр бүлтэй бол, ямар энэ байшинд зай байхгүй биш.

Тэгэж шийдэцгээв. 1420 оны хавар Скромби Роза Кроттонтой гэрлэж (тэр хавар бараг өдөр болгон л хурим болж байв), Уутан хясаанд амьдран суув. Ингээд Фродо энээ тэрээ ажилд санаа зовох юмгүй болсон учир тухтай сууж аваад номоо бичиж эхэллээ. Чөлөөт яармагийн үеэр Фродо ахлагчийн үүрэг гүйцэтгэгчийн ажлаа өгч, өвгөн Вил Дэвсүүртавхай ээлжит долоон жилийн албандаа орж, баяр болгоноор гол ширээнд залардаг болов.

Мерри, Пин хоёр баатар вангийн хуяг дуулгаа өмсөөд, Хоббитани даяар аялж, аян замын паянгаа ярьж, дуу дуулж, найрласаар газар сайгүй алдаршив. Тэр хоёр жигтэйхэн өндөр болсноос биш бусдаар урьдын хэвээрээ, харин ч улам эелдэг, шогч, хөгжилтэй болсон нь бүхний хайрыг татаж байв. Харин Фродо, Сэм хоёр ердийн байдлаар хувцасладаг байсан бөгөөд, зөвхөн цаг агаар тааламжгүй үед урт саарал нөмрөг хөдөрч, нэг л ер бусын товчоор товчилдог, ноён Фродо том сувдан зүүлт хүзүүнээсээ салгалгүй зүүж явдаг, түүнийгээ байнга тэмтэрч үздэг байв.

... Бүх юм сайн сайхан болж, улам л сайхан болсоор байлаа. Сэм дуртай ажилдаа дарагдаж, жаргалын дээдийг эдэлж байсан учир арай л өөртөө атаархсангүй. Эзнийхээ төлөө битүүхэн санаа зовох болоогүйсэн бол тэр жил үнэхээр сайхан жил байв. Фродо хоббитийн амьдралаас анзаарагдалгүй холдож, нутгийнхан нь түүнийг нэг их хүндэтгэхгүй байгааг тэр анзаарчээ. Түүний адал ядал, гавьяаг хэн ч сонирхсонгүй. Харин ноён Мериадок, ноён Перегрин хоёрыг дээд зэргээр хүндэтгэж, бахархсаар байлаа. Сэмийг маш өндөрт өргөдөг байсан ч тэр өөрөө үүнийг анзаарсангүй. Намар нь нөгөөх туулж өнгөрсөн гай зовлонгийн сүүдэр тэднийг дайрав. Нэг орой Сэм эзнийхээ өрөө рүү шагайтал эзэн нь өөрийн ухаангүй юм шиг, царай нь үхсэн мэт цайж, нүд нь үл үзэгдэх алс руу тэмүүлсэн янзтай харагдав.

- Юу болов, ноён Фродо?

- Би шархадсан, их гүн шарх, би эдгэрэхгүй.

Тэр бол аравдугаар сарын зургааны орой, Эргүүлэг уулын дэргэдэх хонхорт харанхуй нөмөрснөөс хойш яг хоёр жилийн ой болж байгааг Сэм тогтоож авчээ.

* * *

Цаг урссаар 1421 он болов. Гуравдугаар сард Фродогийн бие дахин муудсан боловч тэр Сэмийн санааг зовоохгүйн тулд нууж өнгөрөөжээ. Сэмийн ууган хүүхэд хорин тавны өдөр төржээ. Аз жаргалтай эцэг энэ өдрийг хуанлид тэмдэглээд, эзнийхээ өрөөнд оров.

- Би танаас зөвлөгөө авах гэсэн юм, эзэн минь. Роза бид хоёр таныг зөвшөөрвөл хүүхэддээ таниас нэр авах гэсэн юм. Гэхдээ хүү биш, охин шүү дээ. Хүү биш гэж гомдох юм алга, тэгээд ч намайг биш, ээжийгээ дууриасан их хөөрхөн охин. Одоо тэгээд яах вэ?

- Хуучны заншлаа л дагахгүй юу, Сэм. Цэцэгний нэр өг. Эхнэр чинь Сарнай нэртэй шүү дээ. Хоббитуудын тал нь цэцэгний нэртэй, үүнээс өөр сайхан нэр хаана байна?

- Таны зөв байх аа, эзэн минь. Биднийг аялж явахад зөндөө олон чамин тансаг нэр тааралдаж байсан. Тийм чамин тансагийг өдөр тутмын энгийн зүйл болгож болохгүй. Жихарь маань: “Чи богиносгож дуудаж болохооргүй хамгийн богино нэр өг” гэсэн юм. Хэрэв цэцэгний нэр өгөх юм бол урт ч байсан яахав дээ. Гэхдээ маш гоё цэцэг байх ёстой. Охин маань одоо ч нүд салгахын аргагүй хөөрхөн, цаашдаа улам хөөрхөн болно.

Фродо жаахан бодож байснаа:

- Чи Эланор гэдэг нэр өгөхгүй юм уу, Сэм. Кветлориэны нугад нэг тийм гоё өвлийн цэцэг байсныг санаж байна уу?

- Яг оносон нэр, эзэн минь! Бүр яг! – гэж Сэм бахархан дуу алдав.

Бяцхан Эланор зургаан сартай болж, намрын эхэн сар гарсны дараа Фродо Сэмийг өрөөндөө дуудав.

- Пүрэв гаригт Бильбогийн төрсөн өдөр болно, Сэм. Тэр хөгшин Молтогчинг гүйцэж түрүүлсэн. Нэг зуун гучин нэгэн нас хүрч байна.

- Нээрэн тийм шүү! Мөн ч сайн эр юм аа!

- Чи Розатайгаа яриадах, тэр чамайг надтай хамт явуулах нь уу, үгүй юу. Удаан явахгүй, хол ч явахгүй, санаа зовохгүй байж болно.

- Та өөрөө ойлгож байгаа шүү дээ, эзэн минь.

- Ойлгосоод байх юу байгаа юм бэ? Ядаж жаахан дөхүүлээд өгөхгүй юу. Ямар ч гэсэн Розагаас гуйгаад үз. Хоёр долоо хоноод л ирнэ, амьд мэнд бүрэн бүтнээрээ ирнэ, би батлан дааж байна.

- Би тантай хамт Уудам хөндий орж, Бильботой уулзахад асар их баярлах болно. Гэвч миний

байх ёстой газар энд шүү дээ. Би яах юм бэ? Хоёр хэсэг хуваагдалтай биш...

- Мөн ч ядарсан эр юм даа чи! Нэг бол хоёр хуваагдах, нэг бол яаж ч чадахгүй гэх юм. Зүгээрээ, чи нэг бүхэл л байсан, тэр чигээрээ л байх болно.

Маргааш нь Фродо Сэмтэй хамтран бичиг номоо эмхэлж цэгцлээд, бүх түлхүүрээ өгч, хамгийн сүүлд нь час улаан савхин хавтастай зузаан гэгчийн гар бичмэл гардуулав. Тэр номын хуудаснууд эхэндээ Бильбогийн жижигхэн, угалзалсан бичигтэй бөгөөд ихэнх нь Фродогийн гаргац сайтай тогтуухан бичигтэй ажээ. Гар бичмэл олон бүлэгтэй бөгөөд наядугаар бүлэг нь дуусаагүй, хэдэн хуудас цагаанаараа үлджээ. Бүлгүүдийн гарчиг нь:

“Миний тэмдэглэл”, “Миний санамсаргүй аялал”, “Тийшээ ба буцаад”, “Дараа нь болсон явдал”, “Таван хоббитийн адал явдал”, “Бүгдийг захирагч бөгжний тухай тууж”, “Бильбо Торбинсын дурсамжууд болон анд нөхдийн яриа”, “Бөгжний төлөө дайн ба түүнд бидний оролцсон нь” – гэх мэтээр дараалан жагсчээ.

Дараа нь Фродогийн гараар:

БӨГЖНИЙ ЭЗНИЙ МӨХӨЛ БА

ЭЗЭН ХААН ЭРГЭЖ ИРСЭН НЬ

(Хоббитанийн жижиг биет Бильбо, Фродо нарын дурдатгал дээр найз нөхдийн яриа болон Гэгээн Зөвлөлийн Мэргэдийн яриаг нэмэв)

Мөн Уудам хөндийд Бильбогийн тэмдэглэж авсан эртний эльфүүдийн домгийн хэсгээс.

- Ноён Фродо, та бараг бичээд дуусчихсан байна шүү дээ! Та ч энэ жил их ажил хийсэн байна шүү!

- Би бичих юм аа бүгдийг нь бичсэн. Сүүлчийн хуудсуудыг чамд үлдээсэн юм.

Есдүгээр сарын хорин нэгэнд тэд замдаа гарлаа. Фродо Минас-Тиритээс унаж ирсэн Тэнэмэл нэртэй пони морио, Сэм өөрийнхөө хайртай Биллийг унажээ. Цэлмэгхэн, алтан шаргал өглөө байлаа. Сэм хаагуур явахаа асуусангүй, замдаа гараад мэдэж авна гэж бодож байв. Тэр хоёр ойн булан хүртэл хөнгөхөн хатируулав. Ногоон толгодод хоноглоод хорин хоёрны орой их ойн зах руу оров.

- Тэр модыг харж байна уу, хар морьт биднийг гүйцэж ирэхэд та тэр модны ард нуугдсан шүү дээ! – хэмээн Сэм зүүн тийш заагаад: - Зүүд юм шиг л санагдаж байна.

Тэр хоёр аянганд нигүүлсэн царс модны хажуугаар гарч, хуш модны төгөл рүү ороход тэнгэрийн дорно хаяанаас одод гялалзаж эхлэв. Сэм аялалынхаа тухай дурсан санаж, чимээгүй явж байлаа. Төдөлгүй Фродо хуучны аяны дууг аяархан аялж эхлэхийг тэр сонсов. Гэвч үг нь өөр байлаа:

Зүүд нойронд огтхон ч биш

Зузаан хананд хаалга тодорч,

Мэдэхгүй ертөнцийг минь нээж,

Миний өмнө уусах ч юм бил үү.

Нэгэн цагт сарны туяа,

Нууц тэмдэг шиг зам заах болов уу.

Яг энэ дуунд хариулж байгаа юм шиг доод хөндийгөөс ийн дуулах сонсогдов:

А Элберет Гилтониэль

Севрен ренна мириэль

А мэрель эглер Эленнас!

Гилтониэль! О Элберет!

Хөх сүмийн туяа минь ээ!

Холын тэнгисийн чанадах

Мөнхийн гэгээг чинь санаж байна!

Фродо, Сэм хоёр ойн зөөлөн сүүдэрт зогсоод чимээгүй хүлээж байтал замаар хөхөмдөг саарал үүл нүүж ирэх шиг болсноо бүдэгхэн харагдах морьтнуудын цуваа болж хувирав.

Хамгаас түрүүнд Харальд харагдаад, эльфүүдийн сайхан царай гэрэлтэж, тэдний дунд Элронд, Галадриэль хоёр явахыг үзээд Сэм гайхав. Элронд саарал нөмрөг, очир эрдэнийн титэмтэй, гартаа мөнгөн ятга барьсан байв. Түүний хуруунд элфийн гурван бөгжний гол бөгж – Вилья алтан бөгж гялалзана. Галадриэль цагаан морь унаж, цасан цагаан өмсгөл нь сарны намуухан гэрэл мэт туяарна. Түүний хуруунд хүйтэн шөнийн од мэт гялалзсан алмаазан шигтгээтэй мифрил бөгж байгаа нь усыг захирагч Нэнья бөгж билээ. Тэдний араас жижигхэн саарал пони унасан Бильбо Торбинс зүүрмэглэн тонголзож явна.

Элронд тэр хоёртой ихэмсэг бөгөөд эелдгээр мэндэлж, Галадриэль инээмсэглэв:

- Сонин юу байна даа, Сэммиум. Чамайг миний бэлгийг гойд сайн ашигласан гэж би сонссон, одоо өөрөө харж байна. Хоббитани хойшид улам ч сайхан болно, бүр урьдынхаасаа ч хайрламаар болох биз ээ – гэж тэр хэлэв.

Сэм түүнд гүнээ мэхийн ёсолсон боловч хэлэх үг олдсонгүй. Хатан хаан энэ ертөнц дээр хамгийн гоо үзэсгэлэнтэйг тэр мартаж орхижээ.

Бильбо сэрж, нүдээ нээв.

- Аа, Фродо юу! За би өнөөдөр хөгшин Молтогчинг гүйцэж түрүүлээ дээ. Энэ бол шийдэгдсэн асуудал. Одоо алсын замд гарч болно. Чи бидэнтэй хамт явах юм уу?

- Тийм ээ, та нартай хамт. Бөгжтэй хамаатай бүхэн явна.

- Та хаашаа явах гэж, эзэн минь? – гэж юу болж байгааг дөнгөж сая л ойлгосон Сэм дуу алдав..

- Боомт руу, Сэм.

- Намайг орхиж байгаа юм уу?

- Үгүй ээ, Сэм. Орхиогүй. Намайг боомт хүртэл үдэж өг. Чи ч гэсэн бөгжийг богино хугацаанд зүүсэн шүү дээ. Чиний ээлж ч ирэх байх. Чи битгий уйтгарла, Сэм. Хоёр хуваагдаж дууслаа. Чи дахиад олон жил бөхөөс бөх, хатуугаас хатуу байх болно. Амьдар, баярла, бас сайхан хөдөлмөрлө.

- Энэ чинь юу гэсэн үг вэ, би таныг ч гэсэн олон жил баярлана гэж бодсон юмсан. Хоббитани ч цэцэглэнэ, та түүний төлөө...

- Би ч гэсэн тэгж бодож байх шиг байсан. Гэвч ойлгож байна уу, Сэм, би аймшигтай, гүн шархадсан. Би Хоббитанийг аврахыг хүссэн, тэгээд аварлаа, гэхдээ өөрийнхөө төлөө биш. Бүгдээрээ үхэхгүйн тулд нэг нь үхэх хэрэгтэй. Алдахгүйгээр олохгүй. Чи миний өмнөөс үлдэнэ. Би өөрийнхөө биелээгүй амьдралыг чинийх дээр нэмж байна. Чамд Роза байна, Эланор байна, бас Фродо, Розочка, Мериадок, Лютик, Перегрин байх болно. Би тэднийг бараг л харж байх шиг байна. Чиний хоёр гар, чиний саруул ухаан хаа сайгүй хэрэг болно. Мэдээж чамайг Хоббитанийн ахлагчаар сонгоно, чи өөрөө залхаж гүйцтэлээ сонгогдоно, чи хамгийн алдартай цэцэрлэгч болно, хоббитуудад Элаан номыг уншиж өгнө, өнгөрсөн цагийн дурсамжийг хадгалж, агуу их гамшиг хариугүй нөмрөх шахсан тухай сануулж байх болно. Манай сайхан нутгийг бусад хүмүүс улам ихээр хайрлаг. Манай туужид чамд ногдсон бүхнийг чи гүйцээж, урт удаан, аз жаргалтай амьдарна. Харин одоохондоо надтай хамт яв!

Элронд, Галадриэль хоёр Тэнгисийн чанад руу хөвөн одов. Гурав дахь эрин дуусч, түүнтэй хамт эртний бөгжнүүдийн ид шидийн хүч алга болж, гурав дахь мянганы ая дуу, үлгэр домог дуусав. Эльфийн эрхэм дээдэс Дундад газрыг ардаа орхиж, тэдний дунд Сэм, Фродо, Бильбо нар уйтгартай боловч хараахан гунигтай биш явж байлаа.

Тэд үдэш болон шөнөөр Хоббитани дундуур явж өнгөрөхөд зэрлэг амьтдаас өөр хэн ч тэднийг харсангүй, тохиолдлын аянчин зөвхөн моддын хоорондуур гэрэл гялсхийх, өвс ногоон дээгүүр сүүдэр тусахыг л харжээ. Нар баруун зүг рүү хөвсөөр л байв. Хоббитанийн нутгийг өнгөрч, Гэрэлт нурууны өмнөд уулсаар дамжин баруун уулс болон цамхагуудад хүрч, зах хязгааргүй тэнгисийн мандлыг харж, Митлонд буюу Мөнгөлөг боомтыг үзэв.

Боомтын хаалган дээр тэднийг Корабел Сэрдан угтсан бөгөөд тэр өндөр нуруутай, урт буурал сахалтай, нүднээс нь оддын гэгээ цацарч байлаа. Тэрбээр тэднийг тойруулан хараад, мэхийн ёсолж:

- Хөвөхөд бүх зүйл бэлэн – гэж илтгэлээ.

Сэрдан тэднийг Тэнгист, аварга том хөлөг онгоцон дээр хүргэхэд боомтын эрэг дээр мөнгөлөг зүст өндөр морь, дэргэд нь цав цагаан өмсгөлтэй нэгэн зогсч байв. Тэр нааш эргэж, тэдний өөдөөс алхахад Гэндальф бадмаараг шигтгээгээр гялалзах Эльфийн гурав дахь бөгжийг ил зүүснийг Фродо харлаа. Тэгээд бүгдээрээ баярлав. Энэ бол Гэндальф тэдэнтэй хамт хөвнө гэсэн үг билээ.

Гэвч Сэмийн зүрх шимшрэх шиг санагдав. Салах мөч хичнээн харуусалтай байсан ч буцаад ганцаараа урт зам туулна гэдэг зуу дахин уйтгартай болно доо гэж тэр бодож байв. Эльфүүд цагаан хөлгийн тавцан дээр хэрхэн гарч байгааг харж байтал гэнэт морин төвөргөөн сонсогдож, Мерри, Пин хоёр усан хулгана болтол хөлөрсөн морьдынхоо амыг боомтын дэргэд татаж харагдав. Пин асгарах нулимсан дундуураа инээж:

- Чи дахиад л биднээс зугтах гэсэн боловч дахиад л бүтсэнгүй дээ, Фродо. Жаахан л хоцорсон бол өнгөрөх байлаа, гэвч жаахныг тооцохгүй. Энэ удаа чамайг Сэм биш, Гэндальф өөрөө барьж өглөө.

- Тэгсээн, яагаад гэвэл та гурав хамтдаа буцсан нь дээр. За, анд нөхөд минь, энэ тэнгисийн эрэг дээр бидний газар дээрх нөхөрлөл эцэстээ туллаа. Амгалан амьдарцгаагаарай! Битгий уйл гэж би хэлэхгүй, баярын нулимс гэж байдаг юм – гэж Гэндальф хэлэв.

Фродо Мерри, Пин, Сэм нартай үнсэлцээд хөлгийн тавцан дээр гарлаа. Дарвуул өргөгдөж, салхи үлээн, хөлөг онгоц урт булангаар аажуухан хөдлөв. Фродогийн баруун гартаа барьсан Галадриэлийн аяганы тод гэрэл бүдгэрсээр манан дунд замхарлаа. Хөлөг задгай тэнгист орж, баруун зүг хөвлөө. Бороотой шөнөөр Фродо энхрийхэн анхилам үнэр мэдэрч, их усны давалгааны цаанаас нэгэн аялгуу сонсов. Яг л Бомбадилын байшинд зүүдэлсэн шиг борооны саарал манан мөнгөн хөшиг болон хувирч, тэр хөшиг нээгдэхэд гэрэлт эрэг, үүрийн туяа гийсэн алсын ногоон хязгаар үзэгдлээ.

Харин эрэг дээр зогсч байсан Сэмийн хувьд харанхуй сарнисангүй, тэртээ баруун зүгт тэнгисийн саарал долгион хөлөг онгоцны хөнгөн сүүдрийг хэрхэн угааж байгааг харж байлаа. Тэр шөнө дунд өнгөртөл зогсч, тэнгисийн түрэлтийн санаа алдан үглэхийг сонсч, тэрхүү нэгэн хэмийн чимээг зүрх нь уйтгартайяа давтаж байлаа. Дэргэд нь Мерри, Пин хоёр таг дуугүй зогсоно.

Эцэст нь гурвуулаа жолоо эргүүлж, эргэж ч харалгүй удаанаар явахдаа Хоббитани орох замдаа нэг ч үг сольсонгүй, гэвч гурвуулаа явахад зам тийм ч бэрх биш байлаа.

Тэгээд тэд толгодоос бууж, Зүүн зам руу ороод тэндээс Мерри, Пин хоёр Забрэнди рүү эргэж, удалгүй тэр хоёрын хөгжилтэй дуулах нь алсаас сонсогдов. Сэм Голын хөндийн замаар орж, нар жаргаж байхад Уутан хясаанд ирэв. Шингэх нарны сүүлчийн туяа дотроосоо гэрэлтэй байшинг нь гэрэлтүүлж, гэрийнхэн нь түүнийг хүлээж, оройн хоол бэлэн болсон байлаа. Роза түүнийг угтаж, задгай галын дэргэд буйдан сандал дөхүүлж өгөөд, өвөр дээр нь бяцхан Эланорыг суулгав. Сэм гүнээ санаа алдаад.

- Ингээд би хүрээд ирлээ дээ – гэлээ.

Table of Contents

[Өмнөх адал явдлын хураангуй](#)

[Хоббитуудын тухай](#)

[Гаансны өвсний тухай](#)

[Хоббитан нутгийн тохижилтын тухай](#)

[Бөгжний эзэн / Бөгжний ахан дүүс](#)

[НЭГДҮГЭЭР ДЭВТЭР](#)

[Бүлэг 1](#)

[Удаан хүлээсэн дайллага](#)

[Бүлэг 2](#)

[Өнгөрсөн үеийн сүүдэр](#)

[Бүлэг 3](#)

[Аян замд гурвуулаа](#)

[Бүлэг 4](#)

[Мөөгөн дундуур](#)

[Бүлэг 5](#)

[Илэрсэн хуйвалдаан](#)

[Бүлэг 6](#)

[Мөнхийн ой](#)

[Бүлэг 7](#)

[Том Бомбадилынд](#)

[Бүлэг 8](#)

[Булшин дээгүүрх манан](#)

[Бүлэг 9](#)

[Дүүхэлзэгч Пони морь](#)

[Бүлэг 10](#)

[Тэнэмэл](#)

[Бүлэг 11](#)

[Шөнийн илд](#)

[Бүлэг 12](#)

[Эртний их замаар](#)

[Бүлэг 13](#)

[Санамсаргүй зочид](#)

[Бүлэг 14](#)

[Зөвлөл](#)

[Бүлэг 15](#)

[Өмнө зүгт](#)

[Бүлэг 16](#)

[Харанхуйн аялал](#)

[Бүлэг 17](#)

[Морийн гүүр](#)

[Бүлэг 18](#)

[Квэтлориэн](#)

[Бүлэг 19](#)

[Галадриэлийн толь](#)

[Бүлэг 20](#)

[Лориэн минь баяртай](#)

[Бүлэг 21](#)

[Их мөрөн](#)

[Бүлэг 22](#)

[Гарам](#)

[ХОЁРДУГААР ДЭВТЭР](#)

[Бүлэг 1](#)

[Боромир](#)

[Бүлэг 2](#)

[Ристанийн морьт дайчид](#)

[Бүлэг 3](#)

[Урукхай](#)

[Бүлэг 4](#)

[Модон](#)

[Бүлэг 5](#)

[Цагаан морьтон](#)

[Бүлэг 6](#)

[Алтан өргөөт эзэн захирагч](#)

[Бүлэг 7](#)

[Хельмагийн хавцал](#)

[Бүлэг 8](#)

[Изенгард хүрэх замд](#)

[Бүлэг 9](#)

[Хог новш, үнсэн товрог](#)

[Бүлэг 10](#)

[Саруманы сайхан яриа](#)

[Бүлэг 11](#)

[Смеагорлын тус](#)

[Бүлэг 12](#)

[Намаг дундуурх жим](#)

[Бүлэг 13](#)

[Хориотой хаалганы дэргэд](#)

[Бүлэг 14](#)

[Амталж чанасан молтогчин](#)

[Бүлэг 15](#)

[Жаргах нарны цонх](#)

[Бүлэг 16](#)

[Хориотой цөөрөм](#)

[Бүлэг 17](#)

[Замын уулзвар руу](#)

[Бүлэг 18](#)

[Крит - Унголын ойролцоо](#)

[Бүлэг 19](#)

[Шелобын ичээ](#)

[Бүлэг 20](#)

[Сэмийн сонголт](#)

[ГУТГААР ДЭВТЭР](#)

[Бүлэг 1](#)

[Минас Тирит](#)

[Бүлэг 2](#)

[Саарал бүлгийн аян](#)

[Бүлэг 3](#)

[Дайчдын цугларалт](#)

[Бүлэг 4](#)

[Гондорыг дайлаар](#)

[Бүлэг 5](#)

[Мустангримчүүдийн аян дайн](#)

[Бүлэг 6](#)

[Пеленнорын тал дахь тулалдаан](#)

[Бүлэг 7](#)

[Оршуулгын гал](#)

[Бүлэг 8](#)

[Анагаах танхим](#)

[Бүлэг 9](#)

[Сүүлчийн зөвлөл дээр](#)

[Бүлэг 10](#)

[Хаалга нээгдэв](#)

[Бүлэг 11](#)

[Даваан дээрх цамхаг](#)

[Бүлэг 12](#)

[Бүрэнхий хязгаарт](#)

[Бүлэг 13](#)

[Галт уул](#)

[Бүлэг 14](#)

[Кормаллены талд](#)

[Бүлэг 15](#)

[Эзэн хаан](#)

[Бүлэг 16](#)

[Салалт](#)

[Бүлэг 17](#)

[Гэрийн зүг](#)

[Бүлэг 18](#)

[Хоббитанийн гуниг](#)

[Бүлэг 19](#)

[Мөнгөлөг боомт](#)